

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн  
Олон Улсын Стандартын Зөвлөл

International Public Sector Accounting  
Standards Board®



# УЛСЫН СЕКТОРЫН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ОЛОН УЛСЫН ТУНХАГЛАЛУУДЫН ГАРЫН АВЛАГА

## УСНББОУС

БОТЬ I  
2021 он

International Federation of Accountants®  
Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо  
529 тавдугаар өргөн чөлөө  
Нью Йорк, Нью Йорк 10017 АНУ

Энэхүү бүтээлийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ) (International Federation of Accountants (IFAC®))-ноос хэвлэн гаргасан. ДНБХ-ны эрхэм зорилго нь өндөр чанартай, олон улсын стандартын хөгжилд дэмжлэг үзүүлэх, эдгээр стандартын мөрдөлт ба хэрэгжүүлэлтийг хөхүүлэн дэмжих, нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, олон нийтийн эрх ашгийн асуудлуудын талаар саналаа илэрхийлэх замаар нийтийн эрх ашигт үйлчлэх, нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийг хөгжүүлэн бэхжүүлэх явдал юм.

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (International Public Sector Accounting Standards), Саналын Төсөл (Exposure Drafts), Зөвлөлдөх Баримт Бичиг (Consultation Papers), Санал Болгосон Практик Удирдамж (Recommended Practice Guidelines) болон УСНББОУСЗ (IPSASB)-ийн бусад хэвлэлүүдийг ДНБХ (IFAC)-оос хэвлэн гаргасан бөгөөд түүний зохиогчийн эрхэд хамаарна.

Энэхүү хэвлэлд тусгагдсан материалуудад итгэл үзүүлэн үйлдэл хийсэн эсвэл үйлдлээ больсоны улмаас хэн нэгэнд хохирол учирсан тохиолдолд хохирол нь хайнга байдал буюу бусад шалтгаанаар үүссэн эсэхээс үл хамааран УСНББОУСЗ (IPSASB) болон ДНБХ (IFAC) нь уг хохирлын хувьд хариуцлага хүлээхгүй болно.

‘Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл’ (International Public Sector Accounting Standards Board), ‘Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт’ (International Public Sector Accounting Standards), ‘Санал Болгосон Практик Удирдамж’ (Recommended Practice Guidelines), ‘Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо’ (International Federation of Accountants), ‘УСНББОУСЗ’ (IPSASB), ‘УСНББОУС’ (IPSAS), ‘СБПУ’ (RPG), ‘ДНБХ’ (IFAC), ‘УСНББОУСЗ’ (IPSASB) гэсэн лого, ‘ДНБХ’ (IFAC) гэсэн лого нь АНУ болон бусад улс орнууд дахь ДНБХ (IFAC)-ны худалдааны тэмдэг буюу бүртгэгдсэн худалдааны тэмдэг ба үйлчилгээний тэмдэг юм.

Зохиогчийн эрх © 2018 оны 9 дүгээр сар, Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ) (International Federation of Accountants (IFAC)). Бүх эрх хамгаалагдсан. Зөвхөн хувьдаа, худалдаа арилжааны бус зорилгоор ашиглахаас бусад тохиолдолд энэхүү баримт бичгийг хувиран олшруулах, хадгалах, шилжүүлэх буюу бусад адилтгах байдлаар ашиглахын тулд ДНБХ (IFAC)-ноос бичгэн зөвшөөрөл авах шаардлагатай.

Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбооны (International Federation of Accountants) дэргэдэх Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (International Public Sector Accounting Standards Board)-өөс баталсан, 2018 оны 9 дүгээр сард Англи хэл дээр хэвлэн гаргасан энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (International Public Sector Accounting Standards) 2018-ыг Сангийн яам 2019 онд Монгол хэл дээр орчуулах ажлыг гүйцэтгэж, ДНБХ (IFAC)-ны зөвшөөрөлтэйгээр дахин хэвлэсэн болно. Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (International Public Sector Accounting Standards) 2018-ын орчуулгын үйл явцыг ДНБХ (IFAC)-ноос хянасан бөгөөд орчуулгыг “Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (International Federation of Accountants)-ны Хэвлэл Бүтээлүүдийг Орчуулах Бодлого”-ын дагуу гүйцэтгэсэн. ДНБХ (IFAC)-ноос Англи хэл дээр хэвлэн гаргасан Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (International Public Sector Accounting Standards) 2018-ын дээрх текстүүд нь батлагдсан хувь нь байна. ДНБХ (IFAC) нь орчуулгын үнэн зөв, бүрэн бүтэн байдал, эсвэл үүнээс үүдэн гарч болзошгүй үйл явдалд хариуцлага хүлээхгүй болно.

ДНБХ (IFAC)-ноос Англи хэл дээр хэвлэн гаргасан Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (International Public Sector Accounting Standards) © 2018. Бүх эрх хамгаалагдсан.

ДНБХ (IFAC)-ноос хэвлэн гаргасан Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (International Public Sector Accounting Standards) © 2018-ын Монгол хэл дээрх орчуулга. Бүх эрх хамгаалагдсан.

Албан ёсны гарчиг: *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Тунхаглалуудын Гарын Авлага, 2018 оны хэвлэл, ISBN: 978-1-60815-362-6*

Энэхүү баримт бичгийг хувиран олшруулах, хадгалах, шилжүүлэх буюу бусад адилтгах байдлаар ашиглахын тулд [permission@ifac.org](mailto:permission@ifac.org) хаягаар хандана уу.



ДНБХ-ноос хэвлэв

**УЛСЫН СЕКТОРЫН НЯГТЛАН БОДОХ  
БҮРТГЭЛИЙН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ**

**IPSAS®**



ЭНЭ ХУУДСЫГ ЗОРИУД ХООСОН ҮЛДЭЭВ

## Оршил

Дэлхийн нягтлан бодогчдын холбоо (IFAC)-ны дэргэдэх Улсын Секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (УСНББОУСЗ)-өөс баталсан *УСНББОУС-ын 2018 оны хэвлэл* (2018 оны 9 дүгээр сар)-ийг монгол хэл дээр орчуулан та бүхэнд хүргэж байна.

Энэ хэвлэлд өмнө мөрдөгдөж байсан боловч нэмэлт өөрчлөлт орсон стандартуудаас гадна 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

Сангийн яамтай 2018 оны 12 дугаар сард байгуулсан гэрээний дагуу 2018 оны УСНББОУС-ын нэмэлт өөрчлөлт, шинээр батлагдсан стандартуудыг орчуулах ажлыг Л.Бадамханд (ММНБИ), Д.Бүнчинсүрэн (МУИС-ийн БС), Ж.Энхзул (“PWC-аудит” ХХК) гүйцэтгэж, “Севиллиа Аудит” ХХК-ийн ерөнхий захирал Ч. Даваасүрэн “УСНББОУС 2018”-ын орчуулгын хянан найруулгыг; эцсийн шатны хяналт, уншилтыг Сангийн яамны НБББГ-ын ахлах шинжээч, доктор Б.Болормаа нар хийв.

Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хороо 2020 оны 6 дугаар сарын 29-ний өдөр дараах бүрэлдэхүүнтэй хуралдаж, 10 тоот тогтоолоор энэхүү УСНББОУС-ын монгол хэл дээрх орчуулгыг баталсан.

Хорооны дарга:

Хүрэлбаатарын Булгантуяа

Сангийн дэд сайд

Гишүүд:

Чойгүнсэнгийн Чимидсүрэн

Сангийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга, доктор

Будсүрэнгийн Болормаа

Сангийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын ахлах шинжээч, доктор

Цэвэгсүрэнгийн Наранчимэг

Үндэсний аудитын газрын САГ-ын захирал бөгөөд тэргүүлэх аудитор

Баярмагнайгийн Цацрал

Санхүүгийн зохицуулах хорооны хадгаламж зээлийн хоршооны газрын референт

Дагвадоржийн Төрмөнх

Стандартчилал хэмжил зүйн газрын Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газрын мэргэжилтэн

Лхагвацэрэнгийн Бадамханд	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын НББАЗССХ-ны ахлах мэргэжилтэн
Дуламсүрэнгийн Нямаа	МУИС-ийн Бизнесийн сургуулийн нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн дэд проф, доктор
Лувсан-Очирын Дондог	Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнгийн тэргүүн проф, доктор
Гарамдоржийн Гантулга	СЭЗИС-ийн ОУНББСМС-ийн проф, доктор
Дагвын Бүнчинсүрэн	МУИС-ийн Бизнесийн сургуулийн нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн ахлах багш
Батсүхийн Анхтайван	“Делойт-Онч Аудит” ХХК-ийн аудитын менежер
Дуламжавын Энхтуяа	“Худалдаа хөгжлийн банк” ХХК-ийн санхүүгийн удирдлагын хяналтын газрын захирлын орлогч
Чинбатын Байгалмаа	“Клин Энержи” ХХК-ийн санхүүгийн менежер

# УЛСЫН СЕКТОРЫН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ОЛОН УЛСЫН ТУНХАГЛАЛУУДЫН ГАРЫН АВЛАГА

## 2018 ОНЫ ХЭВЛЭЛ

### Энэхүү гарын авлагыг хэрхэн эрэмбэлэн зохион байгуулсан вэ?

Тус гарын авлагын агуулгыг дараах хэсгүүдээр эрэмбэлэн зохион байгуулсан:

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Танилцуулга .....	9
Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбооны үүрэг .....	11
Энэхүү гарын авлагын цар хүрээ .....	13
Гарын авлагын 2017 оны хэвлэлээс хойш орсон мөн чанарын өөрчлөлтүүд .....	15
<b>Боть I-ийн агуулгын хүснэгт .....</b>	<b>17</b>
Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил .....	19
Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал .....	26
Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт-УСНББОУС 1-29 .....	178
<b>Боть II-ын агуулгын хүснэгт .....</b>	<b>1407</b>
Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт-УСНББОУС 30-40 .....	1409
Нягтлан Бодох Бүртгэлийн Мөнгөн Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Танилцуулга.....	2299
Мөнгөн Суурьт УСНББОУС-Нягтлан Бодох Бүртгэлийн Мөнгөн Суурьт Санхүүгийн Тайлагнал .....	2300
Нягтлан Бодох Бүртгэлийн Мөнгөн Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Танилцуулга-2017 онд гаргасан .....	2434
Мөнгөн Суурьт УСНББОУС-Нягтлан Бодох Бүртгэлийн Мөнгөн Суурьт Санхүүгийн Тайлагнал-2017 онд гаргасан .....	2435
Санал Болгосон Практик Удирдамжийн Танилцуулга .....	2565
Санал Болгосон Практик Удирдамж-СБПУ 1-3 .....	2566
УСНББОУС 1-40-ийн Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь .....	2651
2018 оны 01 дүгээр сарын 31-нээр гаргасан Аккруэл суурьт УСНББОУС-ууд .....	2725

### **Зохиогчийн эрх ба орчуулга**

ДНБХ нь УСНББОУСЗ-ийн гарын авлага, стандартууд болон бусад хэвлэлүүдийг хэвлэн гаргаж, зохиогчийн эрхийг өмчилдөг.

Санхүүгийн тайланг бэлтгэгчид ба хэрэглэгчид, аудиторууд, зохицуулагчид, хуульчид, багш судлаачид, оюутнууд болон англи хэлээр ярьдаггүй улс орнуудын бусад сонирхогч бүлгүүд нь өөрсдийн төрөлх хэлээр стандартыг уншиж танилцах нь ач холбогдолтой гэдгийг ДНБХ нь хүлээн зөвшөөрсөн бөгөөд түүний хэвлэл бүтээлүүдийг хувилах буюу орчуулж, дахин хэвлэхийг дэмжин урамшуулдаг.

ДНБХ-ны зохиогчийн эрх бүхий хэвлэл бүтээлүүдийн орчуулга, дахин хэвлэлтийн талаархи түүний бодлогыг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбооноос Хэвлэн Гаргасан Стандартуудыг Орчуулах ба Дахин Хэвлэх Бодлого болон Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбооны Хэвлэл Бүтээлүүдийг Хувилах буюу Орчуулж, Дахин Хэвлэх Бодлого-д заасан байдаг. Энэхүү гарын авлагыг хувилах буюу орчуулж, дахин хэвлэхийг хүсэж буй сонирхогч талууд нь холбогдох нөхцөл, болзлыг тохирохын тулд [permission@ifac.org](mailto:permission@ifac.org) хаягаар хандана уу.

## **УЛСЫН СЕКТОРЫН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл® (УСНББОУСЗ®) нь улсын секторын байгууллагуудад зориулан Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт™ (УСНББОУС™) гэж нэрлэгдэх нягтлан бодох бүртгэлийн стандартуудыг боловсруулдаг. УСНББОУСЗ нь улс орнуудын хоорондох тууштай ба зэрэгцүүлэгдэх санхүүгийн мэдээллийг бий болгохын мэдэгдэхүйц үр өгөөжийг хүлээн зөвшөөрдөг бөгөөд эдгээр өгөөжийг хэрэгжих боломжтой болоход УСНББОУС чухал үүрэг гүйцэтгэнэ гэж найдаж байна. УСНББОУСЗ-ийн Саналын Төсөл болон Зөвлөлдөх Баримт Бичгүүдэд тусгасан саналуудад өөрсдийн санал хүсэлтийг илэрхийлснээр стандартын хөгжилд засгийн газрууд болон үндэсний стандарт тогтоогчид оролцохыг УСНББОУСЗ хүчтэй дэмждэг.

УСНББОУСЗ нь нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурь болон нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуух санхүүгийн тайлагналыг зохицуулдаг УСНББОУС-уудыг гаргадаг. Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын шаардлагууд нь улсын секторт мөрдөгдөх боломжтой тохиолдолд аккруэл суурьт УСНББОУС нь СТОУС-д үндэслэдэг. Мөн аккруэл суурьт УСНББОУС нь СТОУС-д авч үзээгүй, улсын секторын санхүүгийн тайлагналын тусгай асуудлуудыг зохицуулдаг.

УСНББОУС-ыг засгийн газрууд мөрдөх нь дэлхий дахины улсын секторын байгууллагуудын тайлагнаж буй санхүүгийн мэдээллийн чанар ба зэрэгцүүлэгдэх байдлын аль алиныг сайжруулах юм. Өөрсдийн улс оронд нягтлан бодох бүртгэлийн стандартууд болон санхүүгийн тайлагналын удирдамжийг гаргах засгийн газруудын болон үндэсний стандарт тогтоогчдын эрхийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрдөг. УСНББОУСЗ нь УСНББОУС-ыг мөрдөх ба үндэсний шаардлагуудыг УСНББОУС-тай нийцүүлэн уялдуулахыг дэмждэг. Санхүүгийн тайлан нь холбогдох УСНББОУС нэг бүрийн бүх шаардлагуудтай нийцсэн зөвхөн тийм тохиолдолд түүнийг УСНББОУС-тай нийцсэн гэж тодорхойлох хэрэгтэй.

ЭНЭ ХУУДСЫГ ЗОРИУД ХООСОН ҮЛДЭЭВ

## **ДЭЛХИЙН НЯГТЛАН БОДОГЧДЫН ХОЛБООНЫ ҮҮРЭГ**

Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо® (ДНБХ®) нь хүчтэй бөгөөд тогтвортой байгууллага, зах зээл, эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулснаар олон нийтийн эрх ашигт үйлчилдэг. Энэ нь санхүүгийн тайлагналын ойлгомжтой, хариуцлагатай ба зэрэгцүүлэгдэх байдлыг дэмждэг; нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийг хөгжүүлэхэд тусалдаг; глобал санхүүгийн дэд бүтцэд нягтлан бодогчдын үзүүлэх ач холбогдол ба үнэ цэнийг хүргэн танилцуулдаг. 1977 онд үүсгэн байгуулагдсан ДНБХ нь одоогоор олон нийтийн практик, боловсрол, төрийн алба, аж үйлдвэр, худалдааны бараг 3 сая нягтлан бодогчдын төлөөлөх 130 гаруй улс орны 175 гишүүн байгууллага болон хамтрагчидтай болоод байна.

Олон нийтийн эрх ашигт үйлчлэх өөрийн үүрэг, хариуцлагын хүрээнд ДНБХ нь үндсэндээ Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-д дэмжлэг үзүүлснээр өндөр чанартай улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын хөгжүүлэлт, мөрдөлт, хэрэгжүүлэлтэнд хувь нэмрээ оруулдаг. ДНБХ нь энэхүү стандарт тогтоох хараат бус зөвлөлийг хүний нөөцөөр хангаж, удирдлагын болон харилцааны дэмжлэг үзүүлж, санхүүжилт олгодог бөгөөд зөвлөлийн гишүүдийн нэр дэвшүүлэлт ба сонголтын үйл явцад тусалдаг.

УСНББОУСЗ нь хэлэлцэх асуудлуудаа тогтоож, өөрийн хэвлэл бүтээлээ ДНБХ-ны оролцоогүйгээр өөрийн албан үйл ажиллагааны дагуу баталдаг. ДНБХ нь уг хэлэлцэх асуудал буюу хэвлэлүүдэд нөлөө үзүүлэх боломжгүй байдаг. ДНБХ нь тэдгээр гарын авлага, стандартууд болон бусад хэвлэлүүдийг хэвлэн гаргаж, зохиогчийн эрхийг өмчилдөг.

УСНББОУСЗ-ийн хараат бус байдлыг олон арга замаар хамгаалдаг. Үүнд:

- Стандарт тогтоох албан үйл ажиллагаа, түүнчлэн хэлэлцэх асуудлын материал, уулзалт, эцэслэн гаргасан стандарт нэг бүрийн хамт хэвлэсэн дүгнэлтийн үндэслэлтэй олон нийт танилцах ажиллагааны аль алины хувьд бүрэн нээлттэй байдал;
- Стандарт тогтоох үйл явц дахь ажиглагчдын оролцоо;
- УСНББОУСЗ-ийн гишүүд, түүнчлэн нэр дэвшүүлэх/ажиллуулах байгууллагууд нь зөвлөлийн хараат бус, шударга зарчимч, олон нийтийн ашиг сонирхолд нийцэх эрхэм зорилгыг хэрэгжүүлэх шаардлага.

УСНББОУСЗ-ийн Зөвлөх Бүлэг (ЗБ) нь УСНББОУСЗ-ийн албан ёсны зөвлөлдөх үйл явцын салшгүй бөгөөд чухал хэсэг юм. ЗБ-ийн гишүүн байгууллагуудын төлөөлөгчид нь олон талбарын талаар зөвлөгөө өгдөг. Үүнд:

- УСНББОУСЗ-ийн стратеги, ажлын хөтөлбөр ба хэлэлцэх асуудал, үүн дотроо төслийн гол чухал зүйлс;



- УСНББОУСЗ-ийн төслүүд, үүн дотроо УСНББОУС-ын мөрдөлт буюу хэрэгжүүлэлтэнд саад учруулж болох техникийн гол асуудлууд болон шийдвэрлэх асуудлуудын талаархи үзэл баримтлал;
- УСНББОУСЗ-ийн стандарт тогтоох үйл ажиллагаанд хамааралтай бусад асуудлууд.

УСНББОУСЗ нь албан үйл ажиллагааг ёсчлон баримталж, олон нийтийн ашиг сонирхолыг тусгаж буй эсэхийг ханган магадлахын тулд түүний засаглал болон стандарт тогтоох үйл ажиллагаанд Олон Нийтийн Эрх Ашгийн Хороо (ОНЭАХ) хяналт тавьдаг.

ОНЭАХ нь улсын секторын буюу санхүүгийн тайлагналын мэдлэгтэй, түүнчлэн өндөр чанартай ба олон улсын зэрэгцүүлэгдэх санхүүгийн мэдээллийг бэлтгэх ашиг сонирхол бүхий байгууллагуудад мэргэжлийн гэрээт ажлын туршлагатай хүмүүсээс бүрддэг.

Илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах бол ДНБХ-ны [www.ifac.org](http://www.ifac.org) цахим хаягаар хандана уу.

## **ЭНЭХҮҮ ГАРЫН АВЛАГЫН ЦАР ХҮРЭЭ**

### **2018 ОНЫ ХЭВЛЭЛ**

2018 оны 01 дүгээр сарын 31-ний байдлаар УСНББОУСЗ-өөс гаргасан Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандарт (УСНББОУС) болон бусад хэвлэлүүд, Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны талаархи байнгын лавлагаа болох суурь мэдээллийг энэхүү гарын авлагад тусгасан.

ЭНЭ ХУУДСЫГ ЗОРИУД ХООСОН ҮЛДЭЭВ

## ГАРЫН АВЛАГЫН 2017 ОНЫ ХЭВЛЭЛЭЭС ХОЙШ ОРСОН МӨН ЧАНАРЫН ӨӨРЧЛӨЛТҮҮД

### Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-өөс гаргасан Тунхаглалууд

Энэхүү гарын авлага нь улсын секторын санхүүгийн тайлагналын талаархи Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн иж бүрэн цогц тунхаглалуудыг агуулсан.

#### Харилцан лавлагаа

Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д хийсэн харилцан лавлагааг энэхүү гарын авлагад тусгасан. НББОУС болон СТОУС-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон EC4M 6XH, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)

Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

#### Шинэ Стандартууд

УСНББОУСЗ нь дараах Стандартыг батлан гаргасан бөгөөд энэхүү гарын авлагад тусгасан:

- Мөнгөн Суурьт УСНББОУС-Нягтлан Бодох Бүртгэлийн Мөнгөн Суурьт Санхүүгийн Тайлагнал

Энэ нь уг Стандартад дурдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

#### УСНББОУС 25-аас татгалзах

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандарт (УСНББОУС) 25 *Ажилтны Тэтгэмж*-ийг УСНББОУС 39 *Ажилтны Тэтгэмж*-ээр орлуулсан. Үүний үр дүнд УСНББОУС 25-ыг цаашид мөрдөхгүй бөгөөд үүнээс татгалзсан.

ЭНЭ ХУУДСЫГ ЗОРИУД ХООСОН ҮЛДЭЭВ

# АГУУЛГА

## БОТЬ I

	Хуудас
Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил .....	19
Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал .....	26
УСНББОУС 1-Санхүүгийн Тайлангийн Толилуулга .....	178
УСНББОУС 2-Мөнгөн Гүйлгээний Тайлан .....	250
УСНББОУС 3-Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа .....	278
УСНББОУС 4-Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө .....	312
УСНББОУС 5-Зээлийн Өртөг .....	338
УСНББОУС 6-Нэгтгэсэн ба Тусдаа Санхүүгийн Тайлан .....	353
УСНББОУС 7-Хараат Байгууллага дахь Хөрөнгө Оруулалт .....	354
УСНББОУС 8-Хамтарсан Үйлдвэр дэх Хувь Оролцоо .....	355
УСНББОУС 9-Арилжааны Ажил Гүйлгээний Орлого .....	356
УСНББОУС 10-Хэт Инфляцитай Эдийн Засгийн Үеийн Санхүүгийн Тайлагнал .....	387
УСНББОУС 11-Барилгын Гэрээ .....	406
УСНББОУС 12-Бараа Материал .....	436
УСНББОУС 13-Түрээс .....	457
УСНББОУС 14-Тайлангийн Өдрийн Дараах Үйл Явдал .....	496
УСНББОУС 15-Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга ба Толилуулга .....	517
УСНББОУС 16-Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө .....	518
УСНББОУС 17-Үндсэн Хөрөнгө .....	556
УСНББОУС 18-Сегментийн Тайлагнал .....	603
УСНББОУС 19-Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө .....	639
УСНББОУС 20-Холбоотой Талуудын Тодруулга .....	691

УСНББОУС 21-Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт .....	717
УСНББОУС 22-Засгийн Газрын Үндсэн Секторын Талаархи Санхүүгийн Мэдээллийн Тодруулга .....	769
УСНББОУС 23-Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Татвар ба Шилжүүлэг) .....	798
УСНББОУС 24-Санхүүгийн Тайлан дахь Төсвийн Мэдээллийн Толилуулга .....	863
УСНББОУС 26-Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт .....	896
УСНББОУС 27-Хөдөө Аж Ахуй .....	975
УСНББОУС 28-Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга .....	1010
УСНББОУС 29-Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт .....	1106

**УЛСЫН СЕКТОРЫН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН  
ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ОРШИЛ**

**Энэхүү оршлын түүх**

Оршлыг 2000 онд гаргасан.

2004 оны 11 дүгээр сард УСНББОУСЗ нь хянан засварласан *Оршлыг* гаргасан.

2006 оны 12 дугаар сард УСНББОУСЗ нь *Оршил*-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

2012 оны 3 дугаар сард УСНББОУСЗ нь хянан засварласан *Оршлыг* гаргасан.

2016 оны 4 дүгээр сард УСНББОУСЗ нь хянан засварласан *Оршлыг* гаргасан.



2016 оны 4 дүгээр сар

## УЛСЫН СЕКТОРЫН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ОРШИЛ

### АГУУЛГА

---

	Параграф
Танилцуулга	1-4
УСНББОУСЗ-ийн зорилго	5-7
Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Цар Хүрээ ба Бүрэн Эрх	8-23
Стандартуудын цар хүрээ	8-12
Аккруэл ба Мөнгөн Суурьт УСНББОУС	13-15
Мөнгөн Сууриас Аккруэл Суурьт Шилжих	16-19
Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Бүрэн Эрх	20-23
Хэл	24

---

## УЛСЫН СЕКТОРЫН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ОРШИЛ

### Танилцуулга

1. Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ын *Оршил* нь Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн зорилтуудыг тогтоох бөгөөд УСНББОУС-ын цар хүрээ, бүрэн эрхийг тайлбарлана. УСНББОУСЗ-өөс боловсруулж, гаргасан Зөвлөлдөх Баримт Бичиг, бусад хэлэлцүүлгийн баримт материал, Саналын Төсөл, Санал Болгосон Практик Удирдамж болон Стандартуудыг тайлбарлахад лавлагаа болгон ашиглавал зохино.
2. Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Үндсэн хуульд заасанчлан, түүний эрхэм зорилго нь “өндөр чанартай, олон улсын стандарт болон заавар удирдамжийн хөгжил, тэдгээрийн мөрдөлт ба хэрэгжүүлэлтэнд хувь нэмрээ оруулах; хүчтэй нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн байгууллагуудын болон нягтлан бодох бүртгэлийн пүүсүүдийн хөгжил, мэргэжлийн нягтлан бодогчдын өндөр чанартай практик ажиллагаанд дэмжлэг үзүүлэх; мэргэжлийн нягтлан бодогчдын дэлхий дахины үнэ цэнийг хөхүүлэн дэмжих; нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн мэдлэг, туршлага хамгийн их хамааралтай олон нийтийн эрх ашгийн асуудлуудын талаар саналаа илэрхийлэх замаар нийтийн эрх ашигт үйлчлэх явдал” юм. Энэхүү эрхэм зорилгод хүрэхдээ ДНБХ-ны Зөвлөл нь ДНБХ-ны ивээл дор стандарт тогтоох хараат бус байгууллага байдлаар үйл ажиллагаагаа явуулах УСНББОУСЗ-ийг үүсгэн байгуулсан.
3. Доорх 10-р параграфт дурдсанчлан, УСНББОУСЗ нь улсын секторын байгууллагууд ашиглахад зориулсан нягтлан бодох бүртгэлийн стандартууд болон бусад хэвлэл бүтээлүүдийг өөрийн бүрэн эрхийн дагуу боловсруулж, гаргаснаар олон нийтийн эрх ашигт үйлчилдэг.
4. УСНББОУСЗ-ийн гишүүнчлэл, оффисын ажлын нөхцөл, хурал уулзалтын горим, албан үйл ажиллагааны талаархи мэдээллийг ДНБХ-ны Зөвлөлөөс баталсан УСНББОУСЗ-ийн *Ажлын Даалгавар*-т заасан байдаг.

### УСНББОУСЗ-ийн зорилго

5. УСНББОУСЗ-ийн зорилго нь нийтлэг зорилготой санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ дэлхий дахины улсын секторын байгууллагуудын ашиглах өндөр чанартай нягтлан бодох бүртгэлийн стандартууд болон бусад хэвлэл бүтээлүүдийг хөгжүүлэн боловсруулах замаар олон нийтийн эрх ашигт үйлчлэх явдал юм.
6. Энэ нь улсын секторын санхүүгийн менежмент болон шийдвэр гаргалтанд зориулсан илүү сайн мэдээллээр хангаснаар улсын секторын санхүүгийн тайлагналын чанар ба ойлгомжтой байдлыг сайжруулах санаа зорилготой юм. Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхдээ УСНББОУСЗ нь улсын секторын олон

## УЛСЫН СЕКТОРЫН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ОРШИЛ

улсын ба үндэсний нягтлан бодох бүртгэлийн стандартуудын уялдаа, санхүүгийн тайлагналын нягтлан бодох бүртгэлийн болон статистикийн сууриудын нийцлийг тохиромжтой хэмжээгээр хангадаг; мөн түүний стандартууд болон бусад хэвлэл бүтээлүүдийн хүлээн зөвшөөрөлтийг хөхүүлэн дэмждэг.

7. Өөрийн зорилгыг биелүүлэхдээ, УСНББОУСЗ нь дараах хэвлэл бүтээлийг боловсруулж, гаргадаг:
  - Улсын секторын байгууллагуудын нийтлэг зорилготой санхүүгийн тайлан бэлтгэхэд мөрдөх стандартууд болох УСНББОУС.
  - Улсын секторын байгууллагуудын даган мөрдөлтийг дэмжин урамшуулах сайн практик туршлагын талаархи удирдамжаар хангах Санал Болгосон Практик Удирдамж (СБПУ).
  - Улсын секторын санхүүгийн тайлагналын асуудлуудын талаар зөвлөмж гаргах Судалгаа. Энэ нь тухайн авч үзэж буй асуудлуудыг зохицуулах сайн практик болон хамгийн үр дүнтэй аргын талаархи судалгаанд үндэслэдэг.
  - Улсын секторын санхүүгийн тайлагналын асуудлууд болон хөгжлийн талаархи мэдлэг, судалгаанд хувь нэмрээ оруулах мэдээллээр хангах бусад баримт бичиг болон судалгааны тайлан. Эдгээр нь шинэ мэдээлэл буюу шинэлэг үзэл бодлоор хангах эрмэлзэлтэй бөгөөд ном бүтээлийн судалгаа, асуулгын судалгаа, сурвалжлага, туршлага, бодит жишээний судалгаа ба шинжилгээ гэх мэт ерөнхийдөө судалгааны үр дүн байдаг.

### **Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Цар Хүрээ ба Бүрэн Эрх**

#### **Стандартуудын цар хүрээ**

8. УСНББОУСЗ нь аккруэл суурьт нягтлан бодох бүртгэлд мөрдөх УСНББОУС болон мөнгөн суурьт нягтлан бодох бүртгэлд мөрдөх УСНББОУС-ыг боловсруулдаг.
9. УСНББОУС нь нийтлэг зорилготой санхүүгийн тайланд ажил гүйлгээ болон бусад үйл явдлуудыг тусгах шаардлагуудыг тогтоодог. Нийтлэг зорилготой санхүүгийн тайлан нь өөрсдийн мэдээллийн тусгай хэрэгцээ шаардлагыг хангахын тулд санхүүгийн тайлан бэлтгэлтийг тохируулан нийцүүлэхийг шаардах чадвар, боломжгүй тийм хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээг хангахад зориулагдсан санхүүгийн тайлан юм.

УЛСЫН СЕКТОРЫН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ОЛОН УЛСЫН  
СТАНДАРТЫН ОРШИЛ

10. Дараах бүх шалгуурыг хангасан улсын секторын байгууллагуудад<sup>1</sup> мөрдөхийн тулд УСНББОУС-ыг төлөвлөн зохиомжилдог:
- (а) Олон нийтэд үр өгөөж өгөх ба/буюу орлого ба баялагийг дахин хуваарилах үйлчилгээ<sup>2</sup> үзүүлэх үүрэг хариуцлага хүлээдэг;
  - (б) Засгийн газрын бусад түвшнүүдээс авах татвар ба/буюу шилжүүлэг, нийгмийн даатгалын шимтгэл, өр төлбөр буюу үйлчилгээний хөлсөөр өөрсдийн үйл ажиллагааг шууд буюу шууд бусаар ихэвчлэн санхүүжүүлдэг; ба
  - (в) Ашиг олох үндсэн зорилгогүй байх.
11. Тодорхой УСНББОУС-ын мөрдөгдөх боломжтой байдлын аливаа хязгаарлалтыг тэрхүү стандартад тодорхой заадаг. УСНББОУС-ыг материаллаг бус зүйлсэд мөрдөнө гэсэн үг биш юм.
12. УСНББОУС дахь бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд тухайн заалтын бүрэн эрхийг уг ашигласан хэллэгээр тодорхойлох бодлогыг УСНББОУСЗ баримталдаг. Иймээс 2006 оны 01 дүгээр сарын 01-нээс хойш УСНББОУСЗ-өөс баталсан УСНББОУС-ууд нь адил хүчин төгөлдөр үйлчлэх тод хараар болон ердийн хэлбэрээр бичсэн параграфуудыг агуулсан байдаг. Гэхдээ тод хараар бичсэн параграфууд нь үндсэн зарчмуудыг илэрхийлдэг. Тухайн УСНББОУС-ыг түүнд илэрхийлсэн зорилгын агуулга болон Дүгнэлтийн Үндэслэл (хэрэв байгаа бол)-ийн хамт уншвал зохино.

### **Аккруэл ба Мөнгөн Суурьт УСНББОУС**

13. УСНББОУСЗ нь дараах байдлаар УСНББОУС-уудыг боловсруулсан:
- НББОУСЗ-өөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ыг тохиромжтой тохиолдолд улсын секторын нөхцөлд тохируулах замаар түүнтэй нийцүүлэх. СТОУС-аас гажихыг зөвтгөн батлах улсын секторын томоохон асуудал байхаас бусад тохиолдолд ингэж нийцүүлэх үедээ УСНББОУСЗ нь СТОУС-ын нягтлан бодох бүртгэлийн арга болон эх тесктийг боломжит хэмжээгээр хэвээр хадгалахыг эрмэлзэнэ; ба
  - СТОУС-ыг тохируулан мөрдсөнөөр харгалзан тусгаагүй эсвэл түүнд зориулан НББОУСЗ-өөс СТОУС-ыг боловсруулаагүй тийм улсын секторын санхүүгийн тайлагналын асуудлуудыг харгалзан тусгах.
14. Аккруэл суурьт олон УСНББОУС-ууд нь СТОУС-д үндэслэдэг тул НББОУСЗ-ийн *Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал* нь УСНББОУС-ын хэрэглэгчдийн хувьд холбогдох лавлагаа болдог.

<sup>1</sup> УСНББОУС-ыг төлөвлөн зохиомжилсон улсын секторын төрөл бүрийн байгууллагуудыг *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал*-ын 1-р параграфт тодорхойлсон байдаг.

<sup>2</sup> Үйлчилгээ нь бараа, үйлчилгээ, бодлогын зөвлөмж, үүн дотроо улсын секторын бусад байгууллагуудад үзүүлэх үйлчилгээ хамаарна.

УЛСЫН СЕКТОРЫН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ОЛОН УЛСЫН  
СТАНДАРТЫН ОРШИЛ

УСНББОУСЗ нь улсын секторын онолын үзэл баримтлалыг боловсруулах төслийг одоо хэрэгжүүлж байгаа бөгөөд төслийг хэрэгжүүлж дууссанаар уг онолын үзэл баримтлал нь УСНББОУС болон УСНББОУСЗ-ийн бусад хэвлэл бүтээлүүдийн хэрэглэгчдийн хувьд холбогдох лавлагаа болох юм.

15. УСНББОУСЗ нь иж бүрэн Мөнгөн суурьт УСНББОУС-ыг мөн гаргасан бөгөөд энэ нь заавал болон сайн дураар хийх тодруулгын хэсгүүдийг агуулсан байдаг.

**Мөнгөн Сууриас Аккруэл Суурьт Шилжих**

16. Байгууллагын үндсэн санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийн дагуу бэлтгэдэггүй боловч Мөнгөн суурьт УСНББОУС нь аккруэл суурьт мэдээллийг байгууллага сайн дураар тодруулахыг сайшаан дэмждэг. Мөнгөн сууриас аккруэл суурьт нягтлан бодох бүртгэлд шилжиж буй байгууллага нь энэхүү шилжилтийн хугацаанд тухайн аккруэл суурьт тодруулгыг тусган оруулахыг хүсэж болох юм. Нэмэлт мэдээллийн төлөв байдал (жишээлбэл; аудитласан эсвэл аудитлаагүй) ба байршил (жишээлбэл; санхүүгийн тайлангийн тодруулгад эсвэл санхүүгийн тайлангийн тусдаа нэмэлт хэсэгт) нь тухайн мэдээллийн шинж чанар (жишээлбэл; найдвартай ба хамааралтай) болон уг улс орны санхүүгийн тайлагналыг удирдан зохицуулах аливаа хууль тогтоомж буюу зохицуулалтаас хамаардаг.
17. УСНББОУСЗ нь зарим стандартуудад шилжилтийн нөхцөл оруулснаар аккруэл суурьт УСНББОУС-тай нийцүүлэхэд мөн туслалцаа үзүүлэхийг эрмэлздэг. Шилжилтийн нөхцөл оруулснаар энэ нь тухайн аккруэл суурьт УСНББОУС-ын бүх шаардлагуудыг биелүүлэхэд байгууллагад нэмэлт хугацаа олгох буюу УСНББОУС-ыг анх мөрдөх үедээ зарим шаардлагаас чөлөөлөгдөх боломжийг олгож болох юм. Байгууллага нь УСНББОУС-ын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийг мөрдөх сонголтыг дурын хугацаанд хийж болно. УСНББОУС-ын дагуу аккруэл суурьт нягтлан бодох бүртгэлийг мөрдөхөөр шийдвэрлэснээр шилжилтийн нөхцлүүд нь уг шилжилтийг хийх боломжтой хугацааны уртыг тогтоодог. Шилжилтийн нөхцөл дуусах үед байгууллага нь аккруэл суурьт УСНББОУС-тай бүрэн нийцсэн гэж тайлагнадаг.
18. УСНББОУС 1, *Санхүүгийн Тайлангийн Топилуулга*-ын 28-р параграфт дараах шаардлагыг тусгасан байдаг:

Санхүүгийн тайлан нь УСНББОУС-тай нийцдэг бол байгууллага нь ийм нийцлийн талаархи дэлгэрэнгүй, тодорхой мэдэгдлийг уг санхүүгийн тайлангийн тодруулгад илэрхийлнэ. Санхүүгийн тайлан нь УСНББОУС-ын бүх шаардлагуудтай нийцсэн биш л бол байгууллага нь уг санхүүгийн тайланг УСНББОУС-тай нийцсэн гэж илэрхийлж болохгүй.
19. Байгууллага нь аливаа шилжилтийн нөхцлийг мөрдсөн хэмжээгээр тодруулга хийхийг УСНББОУС 1-ээр мөн шаардсан байдаг.

**Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Бүрэн Эрх**

20. Улсын секторын байгууллагуудын нийтлэг зорилготой санхүүгийн тайлан бэлтгэн гаргалтыг улс орон тус бүрийн хувьд зохицуулалтаар удирдан чиглүүлж болох юм. Эдгээр зохицуулалт нь тухайн хамаарах улсын засгийн газар, зохицуулагч байгууллага ба/буюу нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн байгууллагаас томъёолон гаргасан хууль ёсны тайлагналын шаардлагууд, санхүүгийн тайлагналын удирдамж ба заавар, ба/буюу нягтлан бодох бүртгэлийн стандарт хэлбэртэй байж болно.
21. УСНББОУС болон түүнтэй нийцсэн тодруулгыг хамтад нь мөрдсөнөөр улсын секторын байгууллагуудын нийтлэг зорилготой санхүүгийн тайлагналын чанарыг мэдэгдэхүйц сайжруулна гэж УСНББОУСЗ найдаж байна. Эргээд энэ нь засгийн газраас гаргасан нөөцийн хуваарилалтын шийдвэрүүдийн талаархи илүү сайн мэдээлэл бүхий үнэлгээ хийхэд хүргэх төрийн санхүүгийн менежментийг бэхжүүлэх, ингэснээр ойлгомжтой ба хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх магадлалтай юм.
22. УСНББОУСЗ нь УСНББОУС-ыг мөрдөх ба үндэсний шаардлагуудыг УСНББОУС-тай уялдахыг хүчтэй дэмждэг. УСНББОУСЗ нь өөрсдийн улс орондоо нягтлан бодох бүртгэлийн стандартууд ба санхүүгийн тайлагналын удирдамжийг тогтоон мөрдүүлэх засгийн газрын болон үндэсний стандарт тогтоогчдын эрхийг хүлээн зөвшөөрдөг. Зарим бүрэн эрхэт улсын засгийн газар ба үндэсний стандарт тогтоогчид нь өөрсдийн улсын хүрээнд засгийн газрын байгууллагууд болон улсын секторын байгууллагуудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн стандартуудыг нэгэнт боловсруулан гаргаад байна. УСНББОУС-ууд нь илүү сайн зэрэгцүүлэгдэх боломжтой байдалд хувь нэмрээ оруулахын тулд шинэ стандартуудыг боловсруулах буюу одоо байгаа стандартыг хянан засварлахад эдгээр стандарт тогтоогч нарт туслалцаа үзүүлж болох юм. Засгийн газрын байгууллагууд болон улсын секторын байгууллагуудад зориулсан нягтлан бодох бүртгэлийн стандартыг хараахан боловсруулаагүй байгаа улс орнуудад УСНББОУС-ыг үлэмж хэмжээгээр ашиглах магадлалтай юм.
23. УСНББОУСЗ эсвэл нягтлан бодох бүртгэлийн мэргэжил нь дангаараа УСНББОУС-ыг даган мөрдөхийг шаардах бүрэн эрхгүй байдаг. УСНББОУСЗ-ийн хүчин чармайлтын амжилт нь тэдгээр тус тусын улсын хязгаарын хүрээнд үйл ажиллагаа явуулж янз бүрийн олон сонирхогч талуудын зүгээс түүний ажлыг хүлээн зөвшөөрөх ба дэмжих эсэхээс хамааралтай байдаг.

**Хэл**

24. УСНББОУС болон бусад хэвлэлүүдийн албан ёсны текст нь УСНББОУСЗ-өөс англи хэл дээр батлан гаргасан хувилбар юм. ДНБХ-ны гишүүн байгууллагууд нь ДНБХ-ноос зөвшөөрөл авсаны үндсэн дээр тохиромжтой бол өөрийн улс орны хэл дээр хэвлэхийн тулд эдгээр тунхаглалуудыг өөрсдийн зардлаар орчуулан гаргахыг зөвшөөрдөг.

**УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ  
ЗОРИЛГОТОЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ  
БАРИМТЛАЛ**

**Онолын үзэл баримтлалын түүх**

*Онолын Үзэл Баримтлалын Бүлэг 1-4-ийг 2013 оны 01 дүгээр сард гаргасан.*

*Оршил болон Онолын Үзэл Баримтлалын Бүлэг 5-8-ыг 2014 оны 10 дугаар сард гаргасан.*

## АГУУЛГА

---

	Параграф
Оршил	20-24
Бүлэг 1: Онолын үзэл баримтлалын үүрэг ба бүрэн эрх	25-28
Бүлэг 2: Нийтлэг зорилготой санхүүгийн тайлагналын зорилтууд ба хэрэглэгчид	29-46
Бүлэг 3: Чанарын шинжүүд	47-65
Бүлэг 4: Тайлагнагч байгууллага	66-71
Бүлэг 5: Санхүүгийн тайлангийн элементүүд	72-98
Бүлэг 6: Санхүүгийн тайлан дахь хүлээн зөвшөөрөлт	99-103
Бүлэг 7: Санхүүгийн тайлан дахь хөрөнгө, өр төлбөрийн хэмжилт	104-133
Бүлэг 8: Нийтлэг зорилготой санхүүгийн тайлан дахь толилуулга	134-152
Хавсралт: Онолын үзэл баримтлалын албан үйл ажиллагааны хэвлэлүүд	153

---



## Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын Оршил

### Танилцуулга

1. *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал* (Онолын үзэл баримтлал) нь улсын секторын байгууллагуудын<sup>1</sup> нийтлэг зорилготой санхүүгийн тайлан (НЗСТ)-гийн бэлтгэлт ба толилуулгад мөрдөх Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Санал Болгосон Практик Удирдамж (СБПУ)-ийг боловсруулахад хэрэглэх ойлголт ухагдахуунуудыг тогтоодог.
2. Ихэнх улсын секторын байгууллагуудын нэн тэргүүний зорилго нь ашиг олж, хөрөнгө оруулагчдад өмчийн өгөөж хүртээх бус, харин олон нийтэд үйлчилгээ үзүүлэх явдал байдаг. Иймээс санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг шалгаснаар эдгээр байгууллагын гүйцэтгэлийн зөвхөн зарим хэсгийг үнэлж болох юм. НЗСТ нь хариуцлага болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд хэрэглэгчдийг мэдээллээр хангадаг. Иймээс улсын секторын байгууллагуудын НЗСТ-гийн хэрэглэгчдэд ийм асуудлуудын үнэлгээг дэмжих дараах гэх мэт мэдээлэл шаардлагатай болдог:
  - Байгууллага нь иргэд, сонгогчдод үйлчилгээг үр ашигтай ба үр дүнтэй байдлаар үзүүлсэн эсэх;
  - Ирээдүйн зарлагад зориулан одоо бэлэн боломжтой байгаа нөөцүүд болон тэдгээрийн ашиглалтанд ямар хэмжээгээр хязгаарлалт буюу нөхцлүүд тогтоосон эсэх;
  - Одоогийн үйлчилгээний төлөө төлбөр төлөх ирээдүйн татвар төлөгчдөд учрах дарамт ямар хэмжээгээр өөрчлөгдсөн эсэх;
  - Үйлчилгээ үзүүлэх тухайн байгууллагын чадвар боломж нь өмнөх жилтэй харьцуулахад сайжирсан эсвэл муудсан эсэх.
3. Засгийн газрууд нь ерөнхийдөө өргөн эрх мэдэлтэй, үүн дотроо хуулийн шаардлагуудыг тогтоох ба албадан хэрэгжүүлэх, тэдгээр шаардлагуудыг өөрчлөх чадвар боломжтой байдаг. Дэлхий дахинд улсын сектор нь өөрийн үндсэн хуулийн зохицуулалт болон үйл ажиллагааны аргын хувьд ихээхэн харилцан адилгүй байдаг. Гэвч улсын секторын засаглал нь хууль тогтоох байгууллага (буюу үүнтэй адилтгах байгууллага)-ын өмнө гүйцэтгэх засаглал хариуцлага хүлээх нөхцлийг ерөнхийдөө агуулсан байдаг.

---

<sup>1</sup> Улсын секторын байгууллагад үндэсний болон орон нутаг (бүс, муж/аймаг, хөдөө орон нутаг)-ийн засгийн газар болон засгийн газрын холбогдох байгууллагууд хамаардаг. Үүнд мөн улсын секторын олон улсын байгууллагууд хамаарна.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТой  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

4. Онолын үзэл баримтлалыг боловсруулахдаа УСНББОУСЗ-ийн харгалзан үзсэн улсын секторын шинж чанаруудыг дараах хэсгүүдэд онцлон тэмдэглэсэн.

**Арилжааны бус ажил гүйлгээний хэмжээ ба санхүүгийн ач холбогдол**

5. Арилжааны бус ажил гүйлгээний хувьд, байгууллага нь ойролцоогоор тэнцүү үнэ цэнэ бүхий зүйлийг хариу болгон шууд өгөхгүйгээр нөгөө талаас үнэ цэнийг хүлээн авдаг. Ийм ажил гүйлгээ улсын секторт нийтлэг байдаг. Хувь хүн буюу бүлэг хүмүүсийн хүлээн авсан үйлчилгээний түвшин ба чанар нь ногдуулсан татварын түвшинтэй ихэвчлэн шууд хамааралгүй байдаг. Хувь хүн буюу бүлэг хүмүүс нь төлбөр, хураамж төлөх ёстой эсвэл тодорхой үйлчилгээ авахын тулд тусгайлан заасан хувь нэмэр оруулах шаардлагатай байж болох юм. Гэвч хувь хүн буюу бүлэг хүмүүсийн олж авдаг өгөөжийн дүн нь тэдний төлсөн аливаа төлбөр буюу оруулсан хувь нэмэртэй ойролцоогоор тэнцүү биш байдаг учраас ийм ажил гүйлгээ нь ерөнхийдөө арилжааны бус шинж чанартай байдаг. Арилжааны бус ажил гүйлгээний шинж төрөл нь үйлчилгээ хүлээн авагчид болон нөөцөөр хангагчдын зүгээс хийсэн тухайн байгууллагын үнэлгээг хамгийн сайн дэмжихийн тулд хэрхэн хүлээн зөвшөөрөх, хэмжих, толилуулахад нөлөө үзүүлж болох юм.
6. Татвар бол хувь хүн, байгууллага ба засгийн газрын хоорондох хуулиар шаардсан, албан журмын арилжааны бус ажил гүйлгээ юм. Татварыг нэмэгдүүлэх бүрэн эрх нь үндэсний засгийн газрын бүрэн эрх ба орон нутгийн засаг захиргаа, улсын секторын бусад байгууллагуудын бүрэн эрх хоорондох харилцаанаас хамааран харилцан адилгүй байдаг. Улсын секторын олон улсын байгууллагууд нь үндэсний, бүсийн болон мужийн засгийн газрын шилжүүлгээр ихэвчлэн санхүүждэг. Ийм санхүүжилтийг олон улсын гэрээ, конвенциор удирдан зохицуулах буюу сайн дурын үндсэн дээр олгож болох юм.
7. Засгийн газар болон улсын секторын бусад байгууллагууд нь нөөцөөр хангагчид, ялангуяа татвар болон бусад албан журмын ажил гүйлгээний дагуу нөөцөөр хангадаг хүмүүсийн өмнө хариуцлага хүлээдэг. Санхүүгийн тайлагналын хариуцлагын зорилтыг Бүлэг 2, *Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Зорилтууд ба Хэрэглэгчид*-д авч хэлэлцсэн.

**Батлагдсан төсвийн ач холбогдол**

8. Ихэнх засгийн газар болон улсын секторын бусад байгууллагууд нь төсөв бэлтгэдэг. Олон улс орны хувьд хууль тогтоох байгууллага (буюу түүнтэй адилтгах байгууллага)-ын баталдаг төсвийг бэлтгэж, олон нийтэд ил нээлттэй болгох үндсэн хуулийн шаардлага үйлчилдэг. Ийм баримт бичгийн агуулгыг хууль тогтоомжинд ихэвчлэн тодорхойлдог. Хууль тогтоох байгууллага (буюу түүнтэй адилтгах байгууллага) нь хяналт тавьж, сонгогчид ба тэдний сонгосон төлөөлөгчид нь төсөв болон бусад механизмаар дамжуулан тухайн байгууллагын удирдлагын санхүүгийн хариуцлагатай байдлыг тогтоодог. Батлагдсан төсөв нь татварын түвшинг

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

тогтоох суурь үндэслэл ихэвчлэн болдог бөгөөд зарцуулалтын хувьд хууль тогтоох байгууллагын зөвшөөрлийг олж авах үйл явцын нэг хэсэг юм.

9. Батлагдсан төсвийн ачаар санхүүгийн үр дүнг төсөвтэй харьцуулах боломжийг хэрэглэгчдэд олгодог мэдээлэл нь өөрийн санхүүгийн зорилтуудыг улсын секторын байгууллага хэр зэрэг биелүүлж байгааг үнэлэхэд туслалцаа үзүүлдэг. Ийм мэдээлэл нь хариуцлагатай байдлыг сайжруулж, дараагийн төсвийн талаар шийдвэр гаргах нөхцлийг бүрдүүлдэг. Төсөвтэй харьцуулсан тайлагнал нь төрийн санхүүтэй холбоотой хуулийн шаардлагуудын нийцлийг харуулах нийтлэг механизм юм. Хэрэглэгчдийн төсвийн мэдээллийн хэрэгцээ шаардлагыг Бүлэг 2-т авч хэлэлцсэн.

**Улсын секторын хөтөлбөрийн шинж төрөл ба улсын секторын оршин тогтнох хугацаа**

10. Улсын секторын олон хөтөлбөрүүд нь урт хугацаатай байдаг бөгөөд үүрэг амлалтаа биелүүлэх чадвар боломж нь ирээдүйн татвар, шимтгэлээс хамаардаг. Улсын секторын хөтөлбөрүүдээс үүсэх олон үүрэг амлалт ба ирээдүйд татвар ногдуулах бүрэн эрх нь Бүлэг 5, *Санхүүгийн Тайлангийн Элементүүд*-д заасан, өр төлбөр болон хөрөнгийн тодорхойлолтыг хангадаггүй. Иймээс эдгээр үүрэг амлалт ба бүрэн эрхийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрдөггүй.
11. Үүний улмаас санхүүгийн байдлын тайлан болон санхүүгийн үр дүнгийн тайлан нь урт хугацааны хөтөлбөрүүд, ялангуяа нийгмийн үр өгөөж бүхий хөтөлбөрүүдийн талаар хэрэглэгчдэд шаардлагатай бүх мэдээллээр хангаж чаддаггүй. Олон шийдвэрийн санхүүгийн үр дагавар нь ирээдүйн олон жилд, түүнчлэн хэдэн арван жилд нөлөө үзүүлж болох учраас тухайн байгууллагын санхүүгийн болон гол хөтөлбөрүүдийн урт хугацааны тогтвортой байдлын талаархи хэтийн санхүүгийн мэдээлэл бүхий НЗСТ нь Бүлэг 2-т авч хэлэлцсэнчлэн, хариуцлагын ба шийдвэр гаргалтын зорилгын хувьд зайлшгүй шаардлагатай байдаг.
12. Хэдийгээр улс төрийн хяналт байнга өөрчлөгдөж болох боловч үндэстний статус нь ерөнхийдөө маш урт хугацаанд оршин тогтнодог. Санхүүгийн ноцтой хүндрэлд орж, өөрийн бүрэн эрхийн хүрээнд өрийн үүргээ биелүүлж чадахгүй болсон ч гэсэн үндэстний статус оршин тогтносон хэвээр байна. Хэрэв орон нутгийн байгууллагууд нь санхүүгийн хүндрэлд орвол үндэстний засгийн газар нь хамгийн эцсийн найдлага тавих зээлдүүлэгчийн үүргийг гүйцэтгэх буюу томоохон хэмжээний батлан даалт гаргаж болох юм. Орон нутгийн байгууллагуудын үйлчилгээ үзүүлэх гол үүрэг амлалтыг дээд түвшний засгийн газрын байгууллагаас үргэлжлүүлэн санхүүжүүлж болох юм. Өөр зарим тохиолдолд хугацаа хэтэрсэний улмаас өөрсдийн өр төлбөрийг барагдуулах чадваргүй болсон улсын секторын байгууллагуудын үйл ажиллагаанд бүтцийн өөрчлөлт хийснээр цаашид үргэлжлүүлэн оршин тогтнох боломжтой байдаг.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

13. Тасралтгүй байх зарчим нь санхүүгийн тайлан бэлтгэлтийн суурь үндэслэл болдог. 11 ба 12-р параграфт авч хэлэлцсэн асуудлуудыг энэхүү зарчмын тайлбарт тусгах шаардлагатай юм.

**Улсын секторын хөрөнгө, өр төлбөрийн шинж төрөл ба зорилго**

14. Улсын секторын хувьд үндсэн хөрөнгө ба бусад хөрөнгийг эзэмших үндсэн шалтгаан нь тэдний мөнгөн гүйлгээ бий болгох чадварыг биш, харин үйлчилгээний чадавхийг ашиглах явдал байдаг<sup>2</sup>. Үзүүлэх үйлчилгээний төрлөөс шалтгаалан улсын секторын байгууллагуудын ашигладаг хөрөнгийн мэдэгдэхүйц хэсэг нь тусгайлсан шинжтэй, жишээлбэл; авто зам болон цэрэг армийн зориулалттай хөрөнгө байдаг. Ийм хөрөнгүүдийн хувьд хязгаарлагдмал зах зээлтэй байж болох бөгөөд бусад операторууд тэдгээрийг ашиглахын тулд ихээхэн өөрчлөлт тохируулга хийх шаардлагатай байж болно. Эдгээр хүчин зүйлс нь ийм хөрөнгүүдийн хэмжилтэнд нөлөө үзүүлдэг. Эдгээр хөрөнгийн хэмжилтийн сууриудыг Бүлэг 7, *Санхүүгийн Тайлан дахь Хөрөнгө, Өр Төлбөрийн Хэмжилт*-нд авч хэлэлцсэн.
15. Засгийн газар ба улсын секторын бусад байгууллагууд нь үндэстэн буюу бүс нутгийн түүх болон соёлын онцлог шинжид хувь нэмрээ оруулах зүйлсийг эзэмшдэг байж болно. Тухайлбал; урлагийн үнэт зүйлс, түүхэн барилга байгууламж, бусад эд өлгийн зүйлс. Эдгээр байгууллагууд нь байгалийн цогцолборт газар болон тухайн уугуул нутгийн ургамлын аймаг ба амьтны ертөнц бүхий байгалийн чухал ач холбогдолтой бусад газар нутгийг бас хариуцдаг байж болох юм. Хэдийгээр зах зээл нь оршин байлаа ч гэсэн ийм зүйлс болон газар нутгийг ерөнхийдөө худалдан борлуулах зорилгоор эзэмшдэггүй. Харин засгийн газар ба улсын секторын байгууллагууд нь өнөөгийн болон ирээдүйн хойч үедээ зориулан ийм зүйлсийг хамгаалах, унаган төрхөөр хадгалах хариуцлага хүлээдэг.
16. Засгийн газрууд нь ашигт малтмалын нөөц, ус, загасчлах газар, ой мод, цахилгаан соронзон орон гэх мэт байгалийн болон бусад нөөцийн хувьд ихэвчлэн бүрэн эрхтэй байдаг. Бүрэн эрх нь ийм нөөцүүдийг ашиглах лицензийг эзэмшүүлэх буюу тэдгээрийн ашиглалтаас эрхийн шимтгэл ба татвар хураан авах боломжийг засгийн газарт олгодог. Хөрөнгийн тодорхойлолт ба хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг Бүлэг 5 болон Бүлэг 6, *Санхүүгийн Тайлан дахь Хүлээн Зөвшөөрөлт*-нд авч хэлэлцсэн.
17. Засгийн газар ба улсын секторын бусад байгууллагууд нь өөрсдийн үйлчилгээ үзүүлэх зорилтуудтай холбоотойгоор өр төлбөрийг хариуцдаг. Олон өр төлбөр нь арилжааны бус ажил гүйлгээнээс үүсдэг бөгөөд нийгмийн үр өгөөж бүрдүүлэхийн тулд эрхлэн хэрэгжүүлдэг хөтөлбөрүүдтэй холбоотой өр төлбөр нь үүнд хамаарна. Өр төлбөр нь хамгийн эцсийн найдлага тавих зээлдүүлэгч болох тухайн засгийн газрын үүргээс болон гамшигт өртсөн этгээдүүдэд нөөцийг шилжүүлэх аливаа

<sup>2</sup> Улсын секторын олон хөрөнгө нь мөнгөн гүйлгээ үүсгэдэг боловч энэ нь тэдгээрийг эзэмших үндсэн шалтгаан ихэвчлэн биш байдаг.

## УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

үүргээс бас үүсэж болох юм. Мөн түүнчлэн, олон улс орны засгийн газрууд нь гүйлгээн дэх валют гэх мэт мөнгөн үйл ажиллагаанаас үүсэх үүргийг хүлээдэг. Өр төлбөрийн тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг Бүлэг 5 ба 6-д авч хэлэлцсэн.

### Улсын секторын байгууллагуудын зохицуулалтын үүрэг

18. Олон улс орнуудын засгийн газар болон улсын секторын бусад байгууллагууд нь эдийн засгийн зарим салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудыг шууд, эсвэл тусгайлан үүсгэн байгуулсан агентлагаар дамжуулан шууд бусаар зохицуулах бүрэн эрхтэй байдаг. Зохицуулалт хийх төрийн бодлогын гол шалтгаан үндэслэл нь төрийн бодлогын тусгайлан заасан зорилтуудын дагуу олон нийтийн эрх ашгийг хамгаалах явдал юм. Тодорхой үйлчилгээний хувьд зах зээл хомс буюу зах зээлгүй, эсвэл үнэ тогтоолтоор дамжуулан нөлөөллийг нь арилгах боломжгүй орчны орчны бохирдол гэх мэт хүчин зүйлсийг багасгахын тулд зохицуулалтаар бас оролцдог. Ийм зохицуулалтын үйл ажиллагааг хуулийн процессоор хэрэгжүүлдэг.
19. Засгийн газрууд нь мөн өөрийгөө болон улсын секторын бусад байгууллагуудыг зохицуулж болох юм. Ийм зохицуулалт нь хөрөнгө, өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлтийг шаардах эрх ба үүргийг улсын секторын байгууллагуудад үүсгэх, эсвэл ийм зохицуулалтыг өөрчлөх уг улсын секторын байгууллагын чадвар боломж нь тухайн эрх, үүргийг хэрхэн тайлагнахад нөлөөлөх эсэхийг тодорхойлохын тулд шүүн тунгаалт хийх шаардлагатай байж болно. Эдгээр эрх, үүргийг Бүлэг 5-д авч хэлэлцсэн.

### Статистик тайлагналтай холбогдох харилцан хамаарал

20. Олон засгийн газар нь бодит гүйцэтгэлийн хоёр төрлийн санхүүгийн мэдээллийг бэлтгэн гаргадаг. Үүнд: (а) макро эдийн засгийн шинжилгээ болон шийдвэр гаргалтын зорилгоор засгийн газрын үндсэн сектор (ЗГҮС)-ын талаархи засгийн газрын санхүүгийн статистик (ЗГСС); (б) байгууллагын түвшний хариуцлага болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд нийтлэг зорилготой санхүүгийн тайлан (санхүүгийн тайлан), үүн дотроо засгийн газрын тайлагнагч байгууллагын хэмжээний санхүүгийн тайлан.
21. Макро-эдийн засгийн статистикийн ерөнхий стандартуудыг *Үндэсний Тооцооны Систем* (ҮТС)-д тодорхойлсон байдаг. ҮТС нь үндэсний эдийн засаг болон түүний бүрэлдэхүүн хэсгүүд, үүн дотроо ЗГҮС-ын системчилсэн ба нарийвчилсан тайлбар тодорхойлолтод зориулсан үзэл баримтлал юм. Эдгээр стандартуудыг үндэсний болон бүс нутгийн түвшинд хэрэгжүүлдэг. Жишээлбэл; Европын Тооцооны Системээр дамжуулан Европын Холбоонд хэрэгжүүлэх. ЗГСС-ын тайлагналын удирдамжинд Олон Улсын Валютын Сангийн Засгийн Газрын Санхүүгийн Статистикийн гарын авлага хамаардаг.
22. УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайлан ба ЗГСС-т нийцсэн тайланд нийтлэг олон зүйл байдаг. Тайлагналын хоёр үзэл баримтлалын аль алинд

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

нь (а) аккруэл суурьт санхүүгийн мэдээлэл, (б) засгийн газрын хөрөнгө, өр төлбөр, орлого, зардал, (в) мөнгөн гүйлгээний талаархи дэлгэрэнгүй мэдээллийг авч үздэг. Ийм мэдээллийн үндэслэл болох эдгээр тайлагналын хоёр үзэл баримтлалын хувьд нилээд давхардал байдаг.

23. Гэвч УСНББОУС ба ЗГСС-ын тайлагналын удирдамж нь өөр өөр зорилготой юм. Улсын секторын байгууллагуудын санхүүгийн тайлагналын зорилго нь хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд НЗСТ-гийн хэрэглэгчдэд ач холбогдолтой, уг тайлагнагч байгууллагын талаархи мэдээллээр хангах явдал юм. Харин ЗГСС-ын тайланг (а) төсвийн бодлогын хувилбаруудыг шинжлэх, бодлого боловсруулах, төсвийн бодлогын үр нөлөөг үнэлэх, (б) эдийн засагт үзүүлэх үр нөлөөг тодорхойлох, (в) төсвийн үр дүнг үндэсний болон олон улсын хэмжээнд харьцуулахад ашигладаг. Эдийн засагт ЗГҮС-ын болон ерөнхий улсын секторын үзүүлэх үр нөлөөг макро эдийн засгийн статистикийн цогц үзэл баримтлалын хүрээнд үнэлэхэд голлон анхаарал хандуулдаг.
24. Тайлагнагч янз бүрийн байгууллагуудын өөр өөр зорилтууд болон голлон анхаарах зүйлс нь зарим ажил гүйлгээ ба үйл явдлын хувьд нягтлан бодох бүртгэлд ялгаатай арга хэрэглэхэд хүргэдэг. Өөр өөр зорилтууд ба тайлагнагч байгууллагуудын хувьд суурь үндэслэл болохгүй энэхүү нягтлан бодох бүртгэлийн хоёр үзэл баримтлалын хоорондох зөрүүг арилгаж, УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайлан ба ЗГСС-ын тайлангийн аль алиныг бэлтгэх нэг нэгдмэл санхүүгийн мэдээллийн системийг ашиглах нь тайлангийн чанар, цаг хугацаандаа бэлтгэх байдал, ойлгомжтой байдлын хувьд хэрэглэгчдэд үр өгөөжтэй байх юм. Санхүүгийн тайлагналын зорилтууд, тайлагнагч байгууллага, хэмжилт зэргийг тусгасан Бүлэг 2, Бүлэг 4, *Тайлагнагч Байгууллага*, Бүлэг 7-д эдгээр асуудлууд болон тэдгээрийн үр дагаврыг авч хэлэлцсэн.

## **БҮЛЭГ 1: ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ҮҮРЭГ БА БҮРЭН ЭРХ**

### **АГУУЛГА**

---

	Параграф
Онолын үзэл баримтлалын үүрэг	1.1
Онолын үзэл баримтлалын бүрэн эрх	1.2-1.3
Нийтлэг зорилготой санхүүгийн тайлан	1.4-1.7
Онолын үзэл баримтлалын мөрдөгдөх боломжит байдал	1.8
Дүгнэлтийн үндэслэл	

---

## **Онолын үзэл баримтлалын үүрэг**

- 1.1 *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал* (Онолын үзэл баримтлал) нь нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийг мөрддөг улсын секторын байгууллагуудын нийтлэг зорилготой санхүүгийн тайлагнал (санхүүгийн тайлагнал)-ын суурь үндэслэл болох ойлголт ухагдахууныг тогтоодог. Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ) нь улсын секторын байгууллагуудын нийтлэг зорилготой санхүүгийн тайлан (НЗСТ)-г бэлтгэх ба толилуулахад мөрдөх Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Санал Болгосон Практик Удирдамж (СБПУ)-ийг боловсруулахдаа эдгээр ойлголт ухагдахууныг ашиглана.

## **Онолын үзэл баримтлалын бүрэн эрх**

- 1.2 Онолын үзэл баримтлал нь УСНББОУС-ыг мөрддөг улсын секторын байгууллагуудын санхүүгийн тайлагналын бүрэн эрхт шаардлагуудыг тогтоодоггүй, мөн УСНББОУС-ын болон СБПУ-ийн шаардлагуудаас давуутай байдаггүй. НЗСТ-д тайлагнадаг ажил гүйлгээ, бусад үйл явдал болон үйл ажиллагааны хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, толилуулгатай холбоотой бүрэн эрхт шаардлагуудыг УСНББОУС-д тусгайлан заадаг.
- 1.3 Онолын үзэл баримтлал нь УСНББОУС эсвэл СБПУ-д тусгаагүй санхүүгийн тайлагналын асуудлуудыг зохицуулах заавар удирдамжаар хангадаг. Ийм нөхцөлд санхүүгийн тайлан бэлтгэгчид болон бусад талууд нь Онолын үзэл баримтлалд тодорхойлсон нэр томъёоны тодорхойлолт, хүлээн зөвшөөрөлтийн шалгуур, хэмжилтийн зарчим болон бусад ойлголт ухагдахууныг лавлагаа болгох ба харгалзан үздэг.

## **Нийтлэг зорилготой санхүүгийн тайлан**

- 1.4 НЗСТ нь засгийн газрууд болон улсын секторын бусад байгууллагуудын ил тод санхүүгийн тайлагналын гол бүрэлдэхүүн хэсэг бөгөөд түүнийг дэмжиж, бэхжүүлдэг. НЗСТ нь өөрсдийн мэдээллийн тусгай хэрэгцээ шаардлагыг хангахын тулд санхүүгийн тайлан бэлтгэлтийг түүнд тохируулан нийцүүлэхийг шаардах чадвар, боломжгүй тийм хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээг хангахад зориулагдсан санхүүгийн тайлан юм.
- 1.5 Санхүүгийн мэдээллийн зарим хэрэглэгчид нь өөрсдийн мэдээллийн тусгай хэрэгцээ шаардлагыг хангахын тулд тайлан бэлтгэлтийг түүнд тохируулан нийцүүлэхийг шаардах бүрэн эрхтэй байж болно. Ийм талууд нь НЗСТ-гаар хангах мэдээллийг өөрсдийн зорилгод ач холбогдолтой гэж үзэж болох боловч тэдний тухайлсан мэдээллийн хэрэгцээг тусгайлан хангахын тулд НЗСТ-г бэлтгэдэггүй.
- 1.6 НЗСТ нь олон тайлангуудаас бүрдэх магадлалтай бөгөөд тэдгээр тайлан нэг бүр нь санхүүгийн тайлагналын цар хүрээнд хамааруулан тусгах санхүүгийн тайлагналын зорилтууд болон асуудлуудын тодорхой төлөв



## УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

байдалд илүү шууд хариулт өгдөг. НЗСТ нь санхүүгийн тайлангуудаас (өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд цаашид санхүүгийн тайлан гэж нэрлэнэ), үүн дотроо тэдгээрийн тодруулга, түүнчлэн санхүүгийн тайлангуудыг бэхжүүлэн сайжруулах, нэмж гүйцээх, дэлгэрүүлэн баяжуулах мэдээллийн толилуулгаас бүрддэг.

- 1.7 Санхүүгийн тайлагналын цар хүрээ нь НЗСТ-д тайлагнаж болох ажил гүйлгээ, бусад үйл явдал болон үйл ажиллагааны хил хязгаарыг тогтоодог. НЗСТ-гийн үндсэн хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээ болон санхүүгийн тайлагналын зорилтуудаар тухайн санхүүгийн тайлагналын цар хүрээг тодорхойлдог. Санхүүгийн тайлагналын цар хүрээнд юу хамаарч болохыг тодорхойлдог хүчин зүйлсийг дараагийн бүлэгт авч хэлэлцсэн.

### **Онолын үзэл баримтлалын мөрдөгдөх боломжит байдал**

- 1.8 УСНББОУС-ыг мөрддөг улсын секторын байгууллагуудын санхүүгийн тайлагналд энэхүү Онолын үзэл баримтлалыг дагаж мөрдөнө. Иймээс үндэсний, бүс нутгийн, мужийн/аймгийн болон орон нутгийн засаг захиргааны хувьд энэхүү онолын үзэл баримтлалыг мөрдөнө. Онолын үзэл баримтлалыг улсын секторын төрөл бүрийн бусад байгууллагуудад бас мөрддөг. Үүнд:

- Засгийн газрын яам, газар хэлтэс, хөтөлбөр, зөвлөл, комисс, агентлаг;
- Улсын секторын нийгмийн хамгааллын сан, итгэмжлэлийн сан, хууль ёсны эрх бүхий байгууллагууд;
- Засгийн газрын олон улсын байгууллагууд.

## Дүгнэлтийн үндэслэл

ДҮ1.1. УСНББОУСЗ нь санхүүгийн тайлагналын асуудлуудыг авч үзэх тайлан бэлтгэгч нар болон бусад талуудад туслах санаа зорилготойгоор УСНББОУС-ууд болон СБПУ-ийг боловсруулахдаа мөрдөх ойлголт ухагдахууныг онолын үзэл баримтлалд тодорхойлдог. УСНББОУС-ууд нь бүрэн эрхт шаардлагуудыг тусгайлан заадаг. Санал болгосон тусгай шаардлагууд, үүн дотроо янз бүрийн улс орон дахь одоогийн практиктай тэдгээрийн нийцэлтийн талаар саналаа илэрхийлэх боломжийг сонирхогч талуудад олгох албан үйл ажиллагааг хэрэгжүүлсний дараа УСНББОУС болон СБПУ-ийг боловсруулдаг.

ДҮ1.2. Онолын үзэл баримтлал нь УСНББОУС-ыг боловсруулах суурь үндэслэл болдог. Иймээс энэ нь УСНББОУС-ыг дагаж мөрддөг бүх байгууллагад хамааралтай байдаг. Нийт засгийн газрын түвшинд бэлтгэсэн НЗСТ нь уг засгийн газрын бүх байгууллагууд өөрсдийн НЗСТ-даа УСНББОУС-ыг дагаж мөрдсөн эсэхээс үл хамааран тэдгээр байгууллагуудыг бас нэгтгэж болох юм.

## Тусгай зорилготой санхүүгийн тайлан

ДҮ1.3. Стандарт тогтоогчид нь өөрсдийн тодорхой зорилгод хэрэгтэй байгаа мэдээллийг тусгасан санхүүгийн тайлан бэлтгэхийг шаардах бүрэн эрх бүхий тэдгээр хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн бэлтгэсэн санхүүгийн тайланг ихэвчлэн “тусгай зорилготой санхүүгийн тайлан” гэж тодорхойлдог. УСНББОУСЗ нь тусгай зорилготой зарим санхүүгийн тайланг бэлтгэхэд УСНББОУС-ын шаардлагуудыг үр дүнтэй бөгөөд ач холбогдолтойгоор мөрдсөөр байгаа (ба цаашид үргэлжлүүлэн мөрдөж болно) гэдгийг мэддэг.

## Нийтлэг зорилготой санхүүгийн тайлагнал

ДҮ1.4. Хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээг хангахын тулд НЗСТ нь тухайн санхүүгийн тайланг бэхжүүлэн сайжруулах, нэмж гүйцээх, дэлгэрүүлэн баяжуулах мэдээллийг тусган агуулсан байж болно гэдгийг Онолын үзэл баримтлалд онцлон тэмдэглэсэн. Иймээс Онолын үзэл баримтлал нь санхүүгийн тайланд хамруулан харуулснаас илүү дэлгэрэнгүй, санхүүгийн тайлагналын цар хүрээг тусган илэрхийлдэг. Санхүүгийн тайлагналын зорилтууд болон НЗСТ-гийн үндсэн хэрэглэгчдийг энэхүү Үзэл баримтлалын дараагийн бүлэг болох Бүлэг 2, *Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Зорилтууд ба Хэрэглэгчид*-д тодорхойлсон. Санхүүгийн тайлагналын цар хүрээнд тусган хамааруулж болох уг үндсэн хэрэглэгчдийн мэдээллийн магадлалт хэрэгцээ шаардлагын үр дагаврыг энд мөн тусган илэрхийлсэн.

## БҮЛЭГ 2: НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ЗОРИЛТУУД БА ХЭРЭГЛЭГЧИД

### АГУУЛГА

	Параграф
Санхүүгийн тайлагналын зорилтууд	2.1-2.2
Нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн хэрэглэгчид	2.3-2.6
Хариуцлагатай байдал ба шийдвэр гаргалт	2.7-2.10
Үйлчилгээ хүлээн авагчид болон нөөцөөр хангагчдын мэдээллийн хэрэгцээ	2.11-2.13
Нийтлэг зорилготой санхүүгийн тайлангаар хангах мэдээлэл	2.14-2.28
Санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ	2.14-2.17
Төсвийн мэдээлэл ба түүний хууль тогтоомжтой эсвэл нөөцийн бүрдүүлэлт болон ашиглалтыг зохицуулах бусад бүрэн эрхтэй нийцсэн байдал	2.18-2.21
Үйлчилгээ үзүүлэх зорилтын хэрэгжилт	2.22-2.24
Хэтийн санхүүгийн болон санхүүгийн бус мэдээлэл	2.25-2.27
Тайлбар мэдээлэл	2.28
Санхүүгийн тайлан, түүнчлэн тухайн санхүүгийн тайланг бэхжүүлэн сайжруулах, нэмж гүйцээх, дэлгэрүүлэн баяжуулах мэдээлэл	2.29-2.30
Мэдээллийн бусад эх үүсвэр	2.31
Дүгнэлтийн үндэслэл	

## Санхүүгийн тайлагналын зорилтууд

- 2.1 Улсын секторын байгууллагуудын санхүүгийн тайлагналын зорилт нь хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд НЗСТ-гийн хэрэглэгчдэд ач холбогдолтой (цаашид “хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд ач холбогдолтой” гэнэ), уг тайлагнагч байгууллагын талаархи мэдээллээр хангах явдал юм.
- 2.2 Санхүүгийн тайлагнал нь өөрөө төгсгөл биш юм. Түүний зорилт нь НЗСТ-гийн хэрэглэгчдэд ач холбогдолтой мэдээллээр хангах явдал байдаг. Иймээс санхүүгийн тайлагналын зорилтуудыг НЗСТ-гийн хэрэглэгчид болон тэдний мэдээллийн хэрэгцээг харгалзан лавлагаа болгосноор тодорхойлдог.

## Нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн хэрэглэгчид

- 2.3 Иргэд ба бусад үйлчилгээ хүлээн авагчдад төрийн үйлчилгээ үзүүлэхдээ ашиглах зорилгоор засгийн газар болон улсын секторын бусад байгууллагууд нь татвар төлөгчид, хандивлагчид, зээлдүүлэгчид, бусад нөөцөөр хангагчдаас нөөцийг босгож бүрдүүлдэг. Эдгээр байгууллагууд нь тэднийг нөөцөөр хангасан талууд болон шаардлагатай үйлчилгээг үзүүлэхийн тулд тэдгээр нөөцийн ашиглалтаас хамааралтай байдаг талуудын өмнө тухайн нөөцийн менежмент ба ашиглалтын хувьд хариуцлага хүлээдэг. Нөөцөөр хангадаг болон тухайн үйлчилгээ авдаг буюу авахаар хүлээж буй талууд нь шийдвэр гаргалтын зорилгын хувьд орц болох мэдээллийг бас шаарддаг.
- 2.4 Иймээс хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд өөрт шаардлагатай мэдээллийг тусган харуулахыг улсын секторын байгууллагаас шаардах бүрэн эрхгүй үйлчилгээ хүлээн авагчид болон нөөцөөр хангагчдын мэдээллийн хэрэгцээг хангахын тулд улсын секторын байгууллагуудын НЗСТ-г юуны өмнө бэлтгэн гаргадаг. Хууль тогтоогчид (буюу түүнтэй адилтгах байгууллага) болон парламент (буюу түүнтэй адилтгах төлөөллийн байгууллага)-ын гишүүд нь мөн НЗСТ-гийн үндсэн хэрэглэгчид бөгөөд үйлчилгээ хүлээн авагчид ба нөөцөөр хангагчдын эрх ашгийн төлөөлөгч байдлаар өөрийн эрх мэдлийн хүрээнд ажил үүрэг гүйцэтгэх үедээ НЗСТ-г байнга, өргөнөөр ашигладаг. Иймээс Онолын үзэл баримтлалын зорилгын хувьд, НЗСТ-гийн үндсэн хэрэглэгчид нь үйлчилгээ хүлээн авагчид ба тэдний төлөөлөгчид, нөөцөөр хангагчид ба тэдний төлөөлөгчид (өөрөөр зааснаас бусад тохиолдолд цаашид “үйлчилгээ хүлээн авагчид ба нөөцөөр хангагчид” гэж нэрлэнэ) юм.
- 2.5 Иргэд нь засгийн газар болон улсын секторын бусад байгууллагуудаас үйлчилгээг хүлээн авах ба тэднийг нөөцөөр хангадаг. Иймээс иргэд нь НЗСТ-гийн үндсэн хэрэглэгчид юм. Хариуцлага болон шийдвэр гаргалтын зорилгоор өөрт шаардлагатай мэдээллийн хувьд НЗСТ-д найдлага тавьдаг зарим үйлчилгээ хүлээн авагчид ба нөөцөөр хангагчид нь иргэн биш байж болох юм. Жишээлбэл; татвар төлдөг ба/буюу үр өгөөж хүртдэг оршин суугчид нь иргэн биш юм; засгийн газрыг нөөцөөр хангах ба ажил гүйлгээ

## УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

хийдэг олон улсын болон хоёр орны хандивлагч агентлагууд, олон тооны зээлдүүлэгчид болон корпорациуд. Засгийн газрын олон улсын байгууллагуудыг нөөцөөр хангадаг засгийн газруул нь хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд ихэнх тохиолдолд тэдгээр байгууллагуудын НЗСТ-гаас хамааралтай байдаг.

- 2.6 Үйлчилгээ хүлээн авагчид ба нөөцөөр хангагчдын хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд мэдээллийн хэрэгцээг хангахын тулд бэлтгэсэн НЗСТ нь мөн бусад талууд болон бусад зорилгод ач холбогдолтой мэдээллээр хангаж болох юм. Жишээлбэл; засгийн газрын статистикчид, шинжээчид, хэвлэл мэдээллийн байгууллага, санхүүгийн зөвлөгчид, олон нийтийн ашиг сонирхолын болон лобби бүлгүүд, бусад талууд нь НЗСТ-гаар бэлтгэсэн мэдээллийг өөрсдийн тус тусын зорилгод ач холбогдолтой гэж үзэж болох юм. Өөрсдийн мэдээллийн тусгай хэрэгцээ шаардлагыг хангахын тулд санхүүгийн тайлан бэлтгэлтийг түүнд тохируулан нийцүүлэхийг шаардах бүрэн эрх бүхий байгууллагууд нь НЗСТ-гаар бэлтгэсэн мэдээллийг мөн өөрсдийн зорилгод ашиглаж болно. Жишээлбэл; зохицуулагч болон хяналтын байгууллагууд, аудитын байгууллагууд, хууль тогтоогч буюу бусад удирдах байгууллагын дэд хороод, төв агентлагууд ба төсвийн хянагчид, байгууллагын удирдлага, зэрэглэл тогтоогч агентлагууд, зарим тохиолдолд, зээлдүүлэгч байгууллагууд, хөгжлийн болон бусад туслалцаа үзүүлэгч байгууллагууд. Эдгээр бусад талууд нь НЗСТ-гаар бэлтгэсэн мэдээллийг ач холбогдолтой гэж үзэж болох боловч тэд НЗСТ-гийн үндсэн хэрэглэгчид биш юм. Иймээс тэдгээрийн тухайлсан мэдээллийн хэрэгцээг хангахын тулд НЗСТ-г тусгайлан бэлтгэдэггүй.

### **Хариуцлагатай байдал ба шийдвэр гаргалт**

- 2.7 Засгийн газар ба улсын секторын бусад байгууллагын үндсэн чиг үүрэг нь иргэд болон бусад зохих оршин суугчдын сайхан амьдрах нөхцөл байдлыг дээшлүүлэх, түүнийг сахин хамгаалах үйлчилгээ үзүүлэх явдал юм. Тэдгээр үйлчилгээнд тухайлбал, нийгмийн халамжийн хөтөлбөрүүд, хууль тогтоомжийн сахин хэрэгжүүлэлт, нийтийн боловсрол, үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах үйлчилгээ хамаарна. Эдгээр үйлчилгээг ихэнх тохиолдолд арилжааны бус ажил гүйлгээний<sup>3</sup> үр дүн байдлаар өрсөлдөөний бус орчинд үзүүлдэг.
- 2.8 Засгийн газар ба улсын секторын бусад байгууллагууд нь тэднийг нөөцөөр хангасан талууд болон үйлчилгээг үзүүлэхийн тулд тэдгээр нөөцийн ашиглалтаас хамааралтай байдаг талуудын өмнө тухайн тайлант үеийн туршил ба түүнээс хойших урт хугацаанд хариуцлага хүлээдэг. Хариуцлагатай байдлын үүргийн биелүүлэлт нь сонгогчид болон бусад талуудад үйлчилгээ үзүүлэхийн тулд түүнд итгэн хариуцуулсан нөөцийг

<sup>3</sup> Арилжааны ажил гүйлгээ гэдэг нь нэг байгууллага хөрөнгө буюу үйлчилгээг хүлээн авах эсвэл өр төлбөрийг барагдуулах ба хариуд нь нөгөө байгууллагад ойролцоогоор тэнцүү үнэ цэнэ бүхий зүйлийг шууд өгөх ажил гүйлгээ юм. Арилжааны бус ажил гүйлгээ гэдэг нь нэг байгууллага хариуд нь ойролцоогоор тэнцүү үнэ цэнэ бүхий зүйлийг шууд өгөхгүйгээр нөгөө байгууллагаас үнэ цэнийг хүлээн авах ажил гүйлгээ юм.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

тухайн байгууллага хэрхэн удирдан зарцуулсан талаар, түүнчлэн үйлчилгээний нийлүүлэлт ба бусад үйл ажиллагааг удирдан зохицуулах хууль тогтоомж, зохицуулалт буюу бусад бүрэн эрхтэй түүний нийцэлтийн талаархи мэдээлэлтэй байхыг шаарддаг. Улсын секторын байгууллагуудын үзүүлдэг үйлчилгээг санхүүжүүлэх арга зам (үндсэндээ татварын орлого буюу бусад арилжааны бус ажил гүйлгээгээр) ба тэдгээр үйлчилгээний нийлүүлэлтээс уг үйлчилгээ хүлээн авагч нар урт хугацаанд хамааралтай байдгийг харгалзан үзвэл, хариуцлагатай байдлын үүргийн биелэлт нь тухайн тайлант үеийн турш дахь тэрхүү байгууллагын үйлчилгээ үзүүлэх зорилтын хэрэгжилт, ирээдүйн тайлант үеүдэд үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлэх түүний чадавхи гэх мэт асуудлуудын талаархи мэдээлэлтэй байхыг бас шаардана.

2.9 Үйлчилгээ хүлээн авагчид ба нөөцөөр хангагчид нь шийдвэр гаргалтын орц болгохын тулд мэдээллийг бас шаарддаг. Тухайлбал:

- Сайн дурын үндсэн дээр, түүнчлэн арилжааны ажил гүйлгээгээр нөөцөөр хангадаг зээлдүүлэгч, санхүүжүүлэгч, хандивлагчид болон бусад талууд нь засгийн газрын буюу улсын секторын бусад байгууллагын одоогийн ба ирээдүйн үйл ажиллагааг дэмжихийн тулд нөөцөөр хангах эсэх шийдвэрийг гаргадаг. Өөрт шаардлагатай мэдээллийн хувьд НЗСТ-гаас хамааралтай байдаг хууль тогтоогчид буюу түүнтэй адилтгах байгууллагын гишүүд нь засгийн газрын яам, агентлаг, хөтөлбөрийн үйлчилгээ үзүүлэх зорилтууд болон тэдгээрийн хэрэгжилтийг дэмжихийн тулд хуваарилсан нөөцийн талаар зарим тохиолдолд шийдвэр гаргах буюу шийдвэрт нөлөөлдөг; ба
- Татвар төлөгчид нь засгийн газар буюу улсын секторын бусад байгууллагуудад сайн дурын үндсэн дээр эсвэл арилжааны ажил гүйлгээний үр дүнд ихэвчлэн мөнгө санг олгодоггүй. Мөн түүнчлэн, ихэнх тохиолдолд тэд улсын секторын байгууллагын үзүүлдэг үйлчилгээг хүлээн зөвшөөрөх буюу үл зөвшөөрөх сонголт хийх, эсвэл үйлчилгээний өөр нийлүүлэгчийг сонгох эрхгүй байдаг. Иймээс татвар төлөгчид нь засгийн газрыг нөөцөөр хангах, тухайн улсын секторын байгууллагын үзүүлэх үйлчилгээнд нөөцийг хуваарилах, эсвэл тэрхүү үзүүлэх үйлчилгээг худалдан авах буюу ашиглах эсэх талаар шууд нэн даруй шийдвэр гаргах чадвар, боломж багатай байдаг. Гэвч үйлчилгээ хүлээн авагчид болон нөөцөөр хангагчид нь сонгосон албан тушаалтнууд буюу бусад төлөөлөх байгууллагуудын хувьд өөрсдийн санал өгөх давуу эрх болон төлөөллийн хувьд шийдвэр гаргадаг. Эдгээр шийдвэрүүд нь зарим улсын секторын байгууллагуудын хувьд нөөцийн хуваарилалтын үр дагавартай байж болох юм.

2.10 НЗСТ-д хариуцлагын талаар тусгасан мэдээлэл нь шийдвэр гаргалтанд хувь нэмрээ оруулж, мэдээллээр хангадаг. Жишээлбэл; өнгөрсөн хугацаанд үзүүлж байсан үйлчилгээний өртөг, үр ашиг ба үр дүнгийн талаархи мэдээлэл, өртөг нөхөлтийн дүн ба эх үүсвэр, ирээдүйн үйл ажиллагааг дэмжихэд бэлэн боломжтой байгаа нөөц нь хариуцлагыг сахин

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай байдаг. Ийм мэдээлэл нь НЗСТ-гийн хэрэглэгчдийн гаргах шийдвэрт, үүн дотроо тухайн байгууллагыг нөөцөөр хангах эсэх талаар хандивлагчдын болон бусад санхүүгийн дэмжигчдийн гаргах шийдвэрт мөн ач холбогдолтой байдаг.

**Үйлчилгээ хүлээн авагчид болон нөөцөөр хангагчдын мэдээллийн хэрэгцээ**

2.11 Хариуцлага ба шийдвэр гаргалтын зорилгын хувьд үйлчилгээ хүлээн авагчид болон нөөцөөр хангагчдын хувьд дараах гэх мэт асуудлуудын үнэлгээг дэмжих мэдээлэл шаардлагатай байдаг:

- Тайлант үеийн турш дахь тухайн байгууллагын гүйцэтгэл, жишээлбэл:
  - Өөрийн үйлчилгээний нийлүүлэлт, үйл ажиллагааны болон санхүүгийн бусад зорилтуудыг биелүүлэх;
  - Өөрийн хариуцдаг нөөцийг удирдан зохицуулах;
  - Нөөцийг бий болгох ба ашиглахтай холбоотой төсвийн, хууль тогтоох байгууллагын болон бусад бүрэн эрхтэй нийцүүлэн ажиллах;
- Тухайн байгууллагын хөрвөх чадвар (жишээлбэл; одоогийн үүргийг биелүүлэх чадвар) ба төлбөрийн чадвар (жишээлбэл; урт хугацаанд үүргээ биелүүлэх чадвар);
- Байгууллагын үйлчилгээний нийлүүлэлтийн болон бусад үйл ажиллагааны урт хугацааны тогтвортой байдал, тайлант үеийн турш дахь тухайн байгууллагын үйл ажиллагааны үр дүнд тэдгээрт орсон өөрчлөлтүүд, тухайлбал:
  - Өөрийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн санхүүжүүлэх ба үйл ажиллагааны зорилтуудаа ирээдүйд биелүүлсээр байх түүний чадавхи (түүний санхүүгийн чадавхи), үүн дотроо санхүүжилтийн боломжит эх үүсвэр ба өөрийн хяналтанд байдаггүй санхүүжилтээс тухайн байгууллага хамааралтай байх, ингэснээр түүнээс хамааран эмзэг өртөмтгий байх буюу дарамт шахалтанд өртөх хэмжээ;
  - Ирээдүйн тайлант үеүдэд үйлчилгээ үзүүлэлтийг дэмжих одоо бэлэн байгаа биет болон бусад нөөц (түүний үйл ажиллагааны чадавхи);
- Байгууллагын эрхлэн явуулах үйл ажиллагаа болон үзүүлэх үйлчилгээний шинж төрөл буюу бүтэц бүрэлдэхүүнд нөлөөлөх магадлалтай өөрчлөлт нь хүн ам зүйн өөрчлөлт эсвэл дотоодын болон дэлхийн эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлт эсэхээс үл хамааран өөрчлөгдөж буй нөхцөл байдалд зохицох тухайн байгууллагын чадвар.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

2.12 Эдгээр зорилгын хувьд үйлчилгээ хүлээн авагчдад болон нөөцөөр хангагчдад шаардлагатай мэдээлэл нь олон талаар давхцах магадлалтай байдаг. Жишээлбэл; үйлчилгээ хүлээн авагчид нь дараах гэх мэт асуудлыг үнэлэхийн тулд орц болгон ашиглах мэдээллийг шаарддаг:

- Байгууллага нь нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай, үр дүнтэй ба зориулалтын дагуу ашиглаж байгаа бөгөөд ийм ашиглалт нь түүний ашиг сонирхолд нийцэж буй эсэх;
- Тайлант үеийн туршид үзүүлсэн үйлчилгээний хүрээ, хэмжээ, өртөг зардал нь тохиромжтой бөгөөд тэдгээрийн өртөг зардлын нөхөлтийн дүн ба эх үүсвэр;
- Татварын одоогийн түвшин болон үүсгэн бий болгосон бусад нөөц нь одоо үзүүлж буй үйлчилгээний хэмжээ ба чанарыг хадгалахад хангалттай эсэх.

Үйлчилгээ үзүүлэгчид нь ирээдүйн тайлант үеүдэд үзүүлэх үйлчилгээг дэмжих бэлэн боломжтой байгаа нөөцийн хувьд тухайн тайлант үед уг байгууллагын гаргасан шийдвэр болон хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дагавар, тэрхүү байгууллагын хүлээгдэж буй ирээдүйн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа ба түүний зорилтууд, тэдгээр үйл ажиллагааг дэмжихэд шаардлагатай өртөг зардлын нөхөлтийн дүн ба эх үүсвэрийн талаархи мэдээллийг бас шаарддаг.

2.13 Нөөцөөр хангагчид нь дараах гэх мэт асуудлыг үнэлэхийн тулд орц болгон ашиглах мэдээллийг шаарддаг:

- Байгууллага нь тайлант үеийн туршид үүсгэн бий болгосон нөөцийг зөвтгөн батлахуйц байдлаар уг тогтоосоон зорилтууддаа хүрч буй эсэх;
- Байгууллага нь татвар төлөгчдөөс эсвэл зээл болон бусад эх үүсвэрээс тухайн тайлант үед үүсгэн бий болгосон мөнгө сангаар одоогийн үйл ажиллагааг санхүүжүүлсэн эсэх;
- Байгууллага нь ирээдүйд нэмэлт (эсвэл арай бага) нөөц шаардах магадлалтай эсэх, тэдгээр нөөцийн боломжит эх үүсвэр.

Зээлдүүлэгч болон санхүүжүүлэгч нар нь тухайн байгууллагын хөрвөх чадварын, иймээс буцаан төлөлтийн дүн ба хугацаа нь тохиролцсоны дагуу байгаа эсэх үнэлгээний орц болох мэдээллийг шаарддаг. Хандивлагчид нь нөөцийг тухайн байгууллага хэмнэлттэй, үр ашигтай, үр дүнтэй ба зориулалтын дагуу ашиглаж буй эсэх үнэлгээг дэмжих мэдээллийг шаарддаг. Мөн тэд тухайн байгууллагын урьдчилан таамагласан ирээдүйн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа болон нөөцийн хэрэгцээний талаархи мэдээллийг шаарддаг.



## **Нийтлэг зорилготой санхүүгийн тайлангаар хангах мэдээлэл**

### **Санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ**

- 2.14 Засгийн газар буюу улсын секторын бусад байгууллагын санхүүгийн байдлын талаархи мэдээлэл нь тухайн байгууллагын нөөц болон тэдгээр нөөцийн нэхэмжлэлийг тайлангийн өдрөөр тодорхойлох боломжийг хэрэглэгчдэд олгодог. Энэ нь дараах гэх мэт асуудлуудын үнэлгээний орц болох ач холбогдолтой мэдээллээр хангадаг:
- Байгууллагын нөөцийг аюулгүй хадгалах ба удирдан зохицуулах өөрийн үүрэг хариуцлагыг удирдлага ханган биелүүлсэн хэмжээ;
  - Ирээдүйд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг дэмжих бэлэн боломжтой байгаа нөөцийн хэмжээ, тэрхүү нөөцийн дүн, бүтэц бүрэлдэхүүн болон тэдгээр нөөцийн нэхэмжлэлд тухайн тайлант үеийн туршид гарсан өөрчлөлт;
  - Байгууллагын нөөцийн одоо байгаа нэхэмжлэлийг хангах ба буцаан төлөхөд шаардлагатай ирээдүйн мөнгөн гүйлгээний дүн ба хугацаа.
- 2.15 Засгийн газар буюу улсын секторын бусад байгууллагын санхүүгийн үр дүнгийн талаархи мэдээлэл нь уг байгууллага нөөцийг хэмнэлттэй байдлаар олж авсан бөгөөд өөрийн үйлчилгээ үзүүлэх зорилтуудыг биелүүлэхийн тулд тэдгээрийг үр ашигтай ба үр дүнтэйгээр ашигладаг эсэх гэх мэт асуудлуудын үнэлгээг тусган илэрхийлдэг. Үйлчилгээ үзүүлэх өртөг зардал болон тухайн тайлант үеийн турш дахь өртөг зардлын нөхөлтийн дүн ба эх үүсвэрийн талаархи мэдээлэл нь үйл ажиллагааны зардлыг тухайлбал, татвар, хэрэглэгчийн төлбөр, шимтгэл, шилжүүлгээр нөхсөн эсвэл уг байгууллагын өрийн хэмжээг нэмэгдүүлэх замаар санхүүжүүлсэн эсэхийг тодорхойлоход хэрэглэгчдэд тусалдаг.
- 2.16 Засгийн газрын буюу улсын секторын бусад байгууллагын мөнгөн гүйлгээний талаархи мэдээлэл нь санхүүгийн үр дүн, тухайн байгууллагын хөрвөх чадвар болон төлбөрийн чадварын үнэлгээнд хувь нэмрээ оруулдаг. Энэ нь тухайн тайлант үеийн туршид байгууллага хэрхэн мөнгө үүсгэн бий болгож, ашиглан зарцуулсныг, үүн дотроо түүний зээл ба зээлийн буцаан төлөлт, тухайлбал үндсэн хөрөнгийн худалдан авалт ба борлуулалтыг харуулдаг. Мөн энэ нь тухайлбал, татвар ба шилжүүлгээс хүлээн авсан мөнгө, бусад засгийн газар, засгийн газрын агентлаг буюу олон улсын байгууллагаас хүлээн авсан болон шилжүүлсэн мөнгөн гүйлгээг тодорхойлдог. Мөнгөн гүйлгээний мэдээлэл нь мөнгөн гүйлгээний нөхцөлд заасан зарцуулалтын эрхтэй тухайн байгууллагын нийцэлтийн талаархи үнэлгээг бас дэмжих бөгөөд үйлчилгээний нийлүүлэлтийн зорилтуудыг хангахын тулд ирээдүйд шаардлагатай мөнгөн орлогын гүйлгээний магадлалт дүн болон эх үүсвэрийн үнэлгээг тусган мэдээлдэг.
- 2.17 Санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний талаархи мэдээллийг ихэвчлэн санхүүгийн тайланд толилуулдаг. Санхүүгийн тайланд толилуулсан мэдээллийг илүү сайн ойлгох, тайлбарлах ба түүний

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

хүрээнд тусгахад хэрэглэгчдэд туслахын тулд НЗСТ нь тухайн санхүүгийн тайланг бэхжүүлэн сайжруулах, нэмж гүйцээх, дэлгэрүүлэн баяжуулах санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллээр, үүн дотроо засгийн газрын буюу улсын секторын бусад байгууллагын дараах гэх мэт асуудлуудын талаархи мэдээллээр бас хангаж болох юм:

- Түүний үйл ажиллагааг удирдан зохицуулах батлагдсан төсөв ба бусад бүрэн эрхтэй нийцсэн байдал;
- Тухайн тайлант үеийн турш дахь үйлчилгээний нийлүүлэлтийн үйл ажиллагаа ба түүний хэрэгжилт;
- Ирээдүйн тайлант үеүдэд үйлчилгээ үзүүлэлт ба бусад үйл ажиллагааны талаархи хүлээлт, тухайн тайлант үеийн туршид гаргасан шийдвэрийн болон гүйцэтгэсэн үйл ажиллагааны урт хугацааны үр дагавар, үүн дотроо уг ирээдүйн талаархи хүлээлтэнд нөлөөлж болох зүйлс.

Энэхүү мэдээллийг санхүүгийн тайлангийн тодруулгад эсвэл НЗСТ-д тусгасан тусдаа тайланд толилуулж болно.

**Төсвийн мэдээлэл ба түүний хууль тогтоомжтой эсвэл нөөцийн бүрдүүлэлт болон ашиглалтыг зохицуулах бусад бүрэн эрхтэй нийцсэн байдал**

- 2.18 Засгийн газар болон улсын секторын бусад байгууллага нь жилийн төсвийг ихэвчлэн бэлтгэж, батлах ба олон нийтэд ил тод нээлттэй болгодог. Батлагдсан төсөв нь уг байгууллагын дараагийн тайлант үеүдийн үйл ажиллагааны төлөвлөгөө, капиталын хэрэгцээ болон ихэвчлэн түүний үйлчилгээ үзүүлэх зорилтууд ба хүлээлтийн талаархи санхүүгийн мэдээллээр сонирхогч талуудыг хангадаг. Татвар төлөгчид болон бусад нөөцөөр хангагчдаас бүрдүүлсэн нөөцийг зөвтгөн батлахад төсвийг ашигладаг бөгөөд энэ нь нөөцийн зарцуулалтын бүрэн эрхийг тогтоож өгдөг.
- 2.19 Улсын секторын байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих зарим нөөцийг хандивлагчид болон зээлдүүлэгчдээс эсвэл арилжааны ажил гүйлгээний үр дүн байдлаар хүлээн авч болох юм. Гэвч улсын секторын байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих нөөцийг ихэвчлэн батлагдсан төсөвт тусгагдсан хүлээлтийн дагуу татвар төлөгчид болон бусад талуудаас арилжааны бус ажил гүйлгээгээр бүрдүүлдэг.
- 2.20 НЗСТ нь тухайн тайлант үеийн турш дахь уг байгууллагын санхүүгийн үр дүн (“илүүдэл, дутагдал”, “ашиг, алдагдал” болон өөр бусад нэр томъёогоор илэрхийлсэн эсэхээс үл хамаарна), гүйцэтгэл, мөнгөн гүйлгээ, түүнчлэн тайлангийн өдрөөрх түүний хөрөнгө, өр төлбөр болон тэрхүү тайлант үе дэх тэдгээрийн өөрчлөлт, үйлчилгээ үзүүлэх зорилтын хэрэгжилтийн талаархи мэдээллээр хангадаг.
- 2.21 Байгууллагын орлого, зардал, мөнгөн гүйлгээ, санхүүгийн үр дүн нь батлагдсан төсөвт тусгасан тооцоололтой нийцэж буй зэрэг хэмжээ, нөөцийн бүрдүүлэлт болон ашиглалтыг удирдан зохицуулах холбогдох

## УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

хууль тогтоомж буюу бусад бүрэн эрхийг тухайн байгууллага даган мөрдөлтийг үнэлэхэд хэрэглэгчдэд туслах мэдээллийг НЗСТ-д тусган оруулах нь өөрийн санхүүгийн зорилтуудыг тэрхүү улсын секторын байгууллага хэр сайн биелүүлсэн эсэхийг тодорхойлоход чухал ач холбогдолтой байдаг. Ийм мэдээлэл нь засгийн газар буюу улсын секторын бусад байгууллагын өөрийн сонгогчдын өмнө хүлээсэн үүрэг хариуцлагын биелэлтэнд зайлшгүй шаардлагатай бөгөөд уг байгууллагын санхүүгийн гүйцэтгэлийн үнэлгээг бэхжүүлэх ба шийдвэр гаргалтын талаар мэдээлдэг.

### **Үйлчилгээ үзүүлэх зорилтын хэрэгжилт**

- 2.22 Засгийн газрын болон ихэнх улсын секторын байгууллагын үндсэн зорилт нь сонгогчдод шаардлагатай үйлчилгээг үзүүлэх явдал юм. Иймээс засгийн газрын болон ихэнх улсын секторын байгууллагын санхүүгийн гүйцэтгэлийг санхүүгийн үр дүнгийн аливаа хэмжүүрээр бүрэн буюу зохих ёсоор тусган илэрхийлдэггүй. Иймээс тэдний санхүүгийн үр дүнг үйлчилгээ үзүүлэх зорилтуудын хэрэгжилтийн хүрээнд үнэлэх шаардлагатай байдаг.
- 2.23 Тайлант үеийн турш дахь тухайн байгууллагын үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны гарц болон үр дүнгийн тоон хэмжүүр нь зарим тохиолдолд түүний үйлчилгээ үзүүлэх зорилтуудын хэрэгжилтийн талаархи холбогдох мэдээллээр хангадаг. Жишээлбэл; үйлчилгээ үзүүлэх өртөг зардал, тоо хэмжээ, давтамж, түүнчлэн тэдгээр үзүүлсэн үйлчилгээ ба тухайн байгууллагын нөөцийн эх үүсвэрийн харилцан хамаарлын талаархи мэдээлэл. Өөр зарим тохиолдолд, тухайн үзүүлсэн үйлчилгээний чанар буюу тодорхой хөтөлбөрийн үр дүнгийн талаар тайлбар хийснээр уг үйлчилгээ үзүүлэх зорилтуудын хэрэгжилтийг хүргэн танилцуулах шаардлагатай байж болох юм.
- 2.24 Тухайн тайлант үеийн турш дахь үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа, түүний хэрэгжилт ба/буюу үр дүнгийн талаархи санхүүгийн бус, түүнчлэн санхүүгийн мэдээллийн тайлагнал нь уг байгууллагын үйл ажиллагааны хэмнэлт, үр ашиг, үр дүнтэй байдлын үнэлгээний орц мэдээгээр хангадаг. Ийм мэдээллийн тайлагнал нь засгийн газар буюу улсын секторын бусад байгууллага хариуцлагатай байх өөрийн үүргийг биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай юм. Энэ нь сонгогчдоос буюу тэдний нэрийн өмнөөс бүрдүүлсэн нөөцийг тайлагнах ба зөвтгөн баталдаг. Тодорхой байгууллагууд ба хөтөлбөрүүдэд нөөцийг хуваарилах талаар хандивлагчдын гаргасан шийдвэр нь тухайн тайлант үеийн туршид үйлчилгээ үзүүлэх зорилтуудын хэрэгжилт болон ирээдүйд үйлчилгээ үзүүлэх зорилтуудын талаархи мэдээллийн хувьд хамгийн наад зах нь зарим талаар мөн түүний хариулт болдог.

### **Хэтийн санхүүгийн болон санхүүгийн бус мэдээлэл**

- 2.25 Засгийн газар болон засгийн газрын олон хөтөлбөрүүд урт хугацаатай байдгийг харгалзан үзвэл тухайн тайлант үед гаргасан олон шийдвэрийн санхүүгийн үр дагавар нь ирээдүйд зөвхөн олон жилийн дараа тодорхой ойлгомжтой болж болох юм. Хугацааны тодорхой агшин дахь санхүүгийн

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

байдал болон тухайн тайлант үеийн санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээний талаархи мэдээллийг толилуулдаг санхүүгийн тайланг урт хугацааг харгалзан үнэлэх шаардлагатай болдог.

- 2.26 Ирээдүйд үйлчилгээ үзүүлэх ба санхүүжүүлэх хөтөлбөрийн талаар тухайн тайлант үед засгийн газар буюу улсын секторын бусад байгууллагаас гаргасан шийдвэр нь дараах талуудын хувьд мэдэгдэхүйц үр дагавартай байж болно. Үүнд:
- Ирээдүйд тэдгээр үйлчилгээнээс хамааралтай байх сонгогчид;
  - Уг төлөвлөсөн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа болон холбогдох санхүүгийн баталгааг санхүүжүүлэхийн тулд татвар, хураамж төлөх татвар төлөгчид ба сайн дурын бус байдлаар нөөцөөр хангах бусад талуудын одоогийн болон ирээдүйн хойч үеийнхэн.
- 2.27 Байгууллагын урьдчилан таамагласан ирээдүйн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа ба зорилтууд, тухайн байгууллагын ирээдүйн нөөцийн хэрэгцээ шаардлагад тэдгээрийн үзүүлэх магадлалт үр нөлөө ба ийм нөөцийн санхүүжилтийн магадлалт эх үүсвэрийн талаархи мэдээлэл нь засгийн газрын буюу улсын секторын бусад байгууллага ирээдүйд өөрийн үйлчилгээ үзүүлэлтийн болон санхүүгийн хариуцлагаа биелүүлэх түүний чадвар боломжийн аливаа үнэлгээний орц болгоход зайлшгүй шаардлагатай байдаг. НЗСТ дахь ийм мэдээллийн тодруулга нь засгийн газрын буюу улсын секторын бусад байгууллагын үйлчилгээ үзүүлэх тогтвортой байдлын үнэлгээг дэмжиж, тухайн байгууллагын хариуцлагыг бэхжүүлэх бөгөөд шийдвэр гаргалтын зорилгын хувьд ач холбогдолтой нэмэлт мэдээллээр хангадаг.

### **Тайлбар мэдээлэл**

- 2.28 Байгууллагын тухайн тайлант үеийн санхүүгийн болон үйлчилгээний гүйцэтгэлийн суурь үндэслэл болох гол хүчин зүйлс, уг байгууллагын ирээдүйн гүйцэтгэлийн талаархи хүлээлт ба гүйцэтгэлд нөлөөлөх магадлалтай хүчин зүйлсийн үндэслэл болох таамаглалуудын талаархи мэдээллийг НЗСТ-гийн санхүүгийн тайлангийн тодруулгад эсвэл тусдаа тайланд толилуулж болно. Ийм мэдээлэл нь НЗСТ-д тусгасан санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг илүү сайн ойлгох, түүний хүрээнд тусгахад хэрэглэгчдэд тусалдаг бөгөөд хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд ач холбогдолтой мэдээллээр хангах НЗСТ-гийн үүргийг нэмэгдүүлдэг.

### **Санхүүгийн тайлан, түүнчлэн тухайн санхүүгийн тайланг бэхжүүлэн сайжруулах, нэмж гүйцээх, дэлгэрүүлэн баяжуулах мэдээлэл**

- 2.29 Санхүүгийн тайлагналын цар хүрээ нь НЗСТ-д тайлагнаж болох ажил гүйлгээ, бусад үйл явдал болон үйл ажиллагааны хил хязгаарыг тогтоодог. Хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээ шаардлагад хариу өгөхийн тулд Онолын үзэл баримтлал нь санхүүгийн тайланд хамрагдахаас илүү дэлгэрэнгүй байдлаар санхүүгийн тайлагналын цар хүрээг тусган

## УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

илэрхийлдэг. Энэ нь НЗСТ-г бэхжүүлэн сайжруулах, нэмж гүйцээх, дэлгэрүүлэн баяжуулах нэмэлт мэдээллийг уг санхүүгийн тайлангийн хүрээнд толилуулж өгдөг.

- 2.30 Онолын үзэл баримтлал нь санхүүгийн тайланд хамрагдахаас илүү дэлгэрэнгүй байдлаар санхүүгийн тайлагналын цар хүрээг тусган илэрхийлдэг боловч санхүүгийн тайланд толилуулсан мэдээлэл нь санхүүгийн тайлагналын гол цөм хэвээр байдаг. Санхүүгийн тайлангийн элементүүдийг хэрхэн тодорхойлох, хүлээн зөвшөөрөх, хэмжих эсэх, түүнчлэн НЗСТ-гийн хүрээнд тусган оруулах мэдээллийн хувьд хэрэглэж болох толилуулгын ба хүргэн танилцуулалтын хэлбэрийг Онолын үзэл баримтлалын бусад бүлгүүдэд болон бие даасан УСНББОУС-ууд буюу СБПУ-ийг боловсруулах үедээ тохиромжтой байдлаар харгалзан үздэг.

### **Мэдээллийн бусад эх үүсвэр**

- 2.31 НЗСТ нь засгийн газрын буюу улсын секторын бусад байгууллагын хариуцлагатай байх үүргийн биелэлтийг дэмжихэд зайлшгүй шаардлагатай мэдээллийг хүргэн танилцуулах, түүнчлэн шийдвэр гаргалтын зорилгын хувьд орц болох ач холбогдолтой мэдээллээр хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэвч НЗСТ нь хариуцлагатай байдал болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд хэрэглэгчдийн бүх мэдээллийн хэрэгцээг хангах магадлал багатай юм. Жишээлбэл; тайлант үеийн төсөв, гүйцэтгэлийн мэдээллийн харьцуулалтыг НЗСТ-д тусган оруулж болох боловч засгийн газраас гаргасан төсөв ба санхүүгийн прогноз нь засгийн газрын болон улсын секторын бусад байгууллагуудын богино ба дунд хугацааны төлөвлөгөөний санхүүгийн шинж чанаруудын талаархи санхүүгийн болон санхүүгийн бус илүү дэлгэрэнгүй мэдээллээр хангадаг. Засгийн газар ба түүний бие даасан агентлагууд нь үйлчилгээ үзүүлэх одоогийн санал санаачлагуудын хэрэгцээ шаардлага, тогтвортой байдал ба эдийн засгийн урьдчилан таамагласан нөхцөл байдлууд, түүнчлэн ирээдүйн төсөв болон үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ шаардлагад нөлөөлөх тухайн улс орны хүн ам зүйн дунд ба урт хугацааны өөрчлөлтүүдийн талаархи тайланг бас гаргадаг. Иймээс үйлчилгээ хүлээн авагчид болон нөөцөөр хангагчид нь бусад эх үүсвэрээс бий болох мэдээллийг, үүн дотроо эдийн засгийн одоогийн ба урьдчилан таамагласан нөхцөл байдлуудын талаархи тайлан, засгийн газрын төсөв ба прогноз, НЗСТ-д тусган тайлагнаагүй засгийн газрын бодлогын санал санаачлагуудын талаархи мэдээллийг мөн харгалзан үзэх шаардлагатай байж болно.

## Дүгнэлтийн үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь Онолын Үзэл Баримтлалыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### Үндсэн хэрэглэгчдийн бүлэг

ДҮ2.1. Онолын үзэл баримтлалыг боловсруулахдаа, УСНББОУСЗ нь НЗСТ-гийн үндсэн хэрэглэгчдийг уг Онолын үзэл баримтлалд тодорхойлох хэрэгтэй эсэх талаархи санал бодлыг хүлээн авсан. Анхны Зөвлөлдөх Баримт Бичиг<sup>4</sup> хариулт ирүүлсэн олон хүмүүс нь НЗСТ-гийн үндсэн хэрэглэгчдийг Үзэл баримтлалд тодорхойлох хэрэгтэй бөгөөд УСНББОУС-ыг боловсруулах үедээ УСНББОУСЗ нь тэдгээр үндсэн хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээнд голлон анхаарвал зохино гэсэн санал бодлыг илэрхийлсэн. Ийм санал бодлыг УСНББОУСЗ харгалзан үзсэн.

### Үндсэн хэрэглэгчдийн бүлгийг тогтоох

ДҮ2.2. Онолын үзэл баримтлалын Саналын төсөл 1, *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал: Үүрэг, Бүрэн эрх ба Цар хүрээ; Зорилтууд ба Хэрэглэгчид; Чанарын Шинжүүд; Тайлагнагч Байгууллага* (Саналын төсөл)-д үйлчилгээ хүлээн авагчид болон тэдний төлөөлөгчид, нөөцөөр хангагчид болон тэдний төлөөлөгчдийг НЗСТ-гийн үндсэн хэрэглэгчид гэж тодорхойлсон. УСНББОУСЗ нь эдгээр үндсэн хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээг хангахын тулд НЗСТ-гийн агуулгад үндэслэн УСНББОУС болон СБПУ-ийг боловсруулахын явцад санхүүгийн тайлагналыг сонирхож буй бусад талууд нь НЗСТ-г ашиглаж болох бөгөөд НЗСТ нь тэдгээр бусад хэрэглэгчдийн ашиглах мэдээллээр хангаж болох юм.

ДҮ2.3. Саналын Төсөлд хариулт ирүүлсэн олон хүмүүс нь үйлчилгээ хүлээн авагчид болон тэдний төлөөлөгчид, нөөцөөр хангагчид болон тэдний төлөөлөгчдийг НЗСТ-гийн үндсэн хэрэглэгчид гэж тодорхойлохыг дэмжиж байгаагаа илэрхийлсэн. Гэвч зарим хүмүүс нь олон нийт, иргэд болон хууль тогтоогч байгууллагыг улсын секторын байгууллагуудын НЗСТ-гийн үндсэн буюу хамгийн чухал хэрэглэгч гэж тодорхойлох хэрэгтэй гэсэн саналтай байсан. Яагаад гэвэл, засгийн газрууд нь иргэд буюу өөрсдийн төлөөлөгчдийн өмнө анхдагч хариуцлага хүлээдэг бөгөөд олон улс оронд хууль тогтоогч байгууллага буюу иргэдийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж буй парламент (буюу үүнтэй адилтгах төлөөллийн байгууллага)-ын бие даасан гишүүд нь НЗСТ-гийн үндсэн хэрэглэгчид байдаг гэж тэд тайлбарласан. Хариулт өгсөн өөр зарим хүмүүс нь зөвхөн нөөцөөр хангагчид болон тэдний төлөөлөгчдийг улсын секторын байгууллагуудын НЗСТ-гийн үндсэн хэрэглэгч гэж тодорхойлох хэрэгтэй гэсэн санал бодлыг

---

<sup>4</sup> Зөвлөлдөх Баримт Бичиг, *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал: Санхүүгийн Тайлагналын Зорилтууд; Санхүүгийн Тайлагналын Цар Хүрээ; Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайланд тусгасан Мэдээллийн Чанарын Шинжүүд; Тайлагнагч байгууллага.*

## УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

илэрхийлж байсан. НЗСТ нь бүх хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээг хангах магадлал багатай бөгөөд нөөцөөр хангагчид нь НЗСТ-г хамгийн их сонирхох магадлалтай гэж тэд тайлбарласан. Ингэж нөөцөөр хангагчдыг үндсэн хэрэглэгчдийн бүлэг гэж тодорхойлох нь УСНББОУСЗ зөвхөн ганц хэрэглэгчийн бүлгийн мэдээллийн хэрэгцээнд илүү онцгойлон анхаарах боломж олгох юм. Түүнчлэн, нөөцөөр хангагчдын мэдээллийн хэрэгцээг хангахын тулд бэлтгэсэн НЗСТ нь бусад боломжит хэрэглэгчдэд ач холбогдолтой мэдээллээр бас хангах магадлалтай гэж тэд онцлон тэмдэглэсэн.

ДҮ2.4. Улсын секторын байгууллагуудын НЗСТ-гийн үндсэн хэрэглэгчдийн тодорхойлолтын талаар хариулт өгсөн хүмүүсийн гаргасан олон саналууд ач тустай, ялангуяа олон улс орны засгийн газрууд тэдгээр саналыг харгалзан мөрдөх тул ач холбогдолтой гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Гэвч улсын секторын байгууллагуудын санхүүгийн тайлагналын зорилтуудыг харгалзан үзсэнээр УСНББОУСЗ нь улсын секторын байгууллагуудын НЗСТ-гийн үндсэн хэрэглэгчид бол үйлчилгээ хүлээн авагчид болон тэдний төлөөлөгчид, нөөцөөр хангагчид болон тэдний төлөөлөгчид гэж тодорхойлох хэрэгтэй гэсэн байр сууриа хэвээр хадгалсан. Яагаад гэвэл:

- Засгийн газар болон улсын секторын бусад байгууллагууд нь шаардлагатай үйлчилгээг үзүүлэхийн тулд нөөцийн ашиглалтаас хамааралтай байдаг талууд, түүнчлэн тэдгээр үйлчилгээг үзүүлэх боломж олгох нөөцөөр хангадаг талуудын өмнө хариуцлага хүлээдэг; ба
- НЗСТ нь шийдвэр гаргах зорилгын хувьд тэдгээр хэрэглэгчдэд ач холбогдолтой мэдээллээр хангах болон уг хариуцлагыг биелүүлэхэд чухал үүрэгтэй байдаг.

Иймээс үндсэн хэрэглэгчид болох үйлчилгээ хүлээн авагчид болон тэдний төлөөлөгчид, нөөцөөр хангагчид болон тэдний төлөөлөгчдийн мэдээллийн хэрэгцээг хангахын тулд НЗСТ-г бэлтгэх хэрэгтэй. Мөн түүнчлэн, Онолын үзэл баримтлалыг засгийн газрууд болон олон улс орны улсын секторын бусад янз бүрийн байгууллагууд, засгийн газрын олон улсын байгууллагууд мөрддөг. Ийм учраас бусад хэрэглэгчдийн бүлгийг НЗСТ-гийн үндсэн хэрэглэгчид гэж тодорхойлох нь бүх улс орны бүх улсын секторын байгууллагуудад хамааралтай бөгөөд үр дүнтэй байх эсэх нь тодорхойгүй юм.

ДҮ2.5. НЗСТ дахь зарим мэдээлэл нь бусад хэрэглэгчидтэй харьцуулахад зарим хэрэглэгчдийн хувьд илүү сонирхолтой бөгөөд илүү ихээр ашиглагддаг байж болно гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Үндсэн хэрэглэгчдийн янз бүрийн бүлгүүдийн хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэх ба зарим тохиолдолд тэдгээрийн тэнцвэрийг хангах шаардлагатай гэдгийг УСНББОУСЗ нь УСНББОУС-ууд болон СБПУ-ийг боловсруулах үедээ мөн хүлээн зөвшөөрсөн. Гэвч ийм асуудлууд нь үйлчилгээ хүлээн авагчид ба тэдний төлөөлөгчид, нөөцөөр хангагчид ба тэдний төлөөлөгчдийн аль

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

алиныг НЗСТ-гийн үндсэн хэрэглэгчид гэж тодорхойлохыг үгүйсгэхгүй гэдэгт УСНББОУСЗ итгэлтэй байна.

ДҮ2.6. Хариулт ирүүлсэн хүмүүсийн тодорхойлсон үндсэн хэрэглэгчийн бүлгүүд ба үйлчилгээ хүлээн авагчид, нөөцөөр хангагчдын хоорондох харилцан хамаарлын талаархи УСНББОУСЗ-ийн байр суурийг доор нарийвчлан тайлбарласан болно.

*Иргэд*

ДҮ2.7. УСНББОУСЗ нь НЗСТ-гийн үндсэн хэрэглэгчид болохын хувьд иргэд, олон нийт болон тэдний төлөөлөгчдийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрдөг боловч иргэдийг үйлчилгээ хүлээн авагчид ба нөөцөөр хангагчид гэж ангилах нь тэдний мэдээллийн боломжит хэрэгцээ шаардлагыг үнэлэх суурь үндэслэлээр хангана гэсэн үзэл бодолтой байдаг. Яагаад гэвэл, иргэд нь боломжит өргөн хүрээний янз бүрийн мэдээллийн хэрэгцээ бүхий олон хүмүүсээс бүрддэг - үйлчилгээ хүлээн авагчид ба нөөцөөр хангагчид байдлаар иргэдийн мэдээллийн хэрэгцээнд анхаарал хандуулах нь УСНББОУСЗ тэдгээр янз бүрийн ашиг сонирхлыг нэгтгэж, НЗСТ-гаар хангахыг эрмэлзвэл зохих мэдээллийн хэрэгцээг харгалзан судлахад хүргэх юм. Мөн УСНББОУС-ыг боловсруулахдаа УСНББОУСЗ нь иргэд (үүн дотроо, хандивлагчид ба зээлдүүлэгчид) биш тийм үйлчилгээ хүлээн авагчид ба нөөцөөр хангагчдын мэдээллийн хэрэгцээг харгалзан үзэх чадамжтай байх хэрэгтэй бөгөөд хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд иргэдэд шаардлагатай мэдээллийг тусган толилуулахыг улсын секторын байгууллагаас тэрээр шаардах бүрэн эрхгүй гэсэн байр суурьтай байсан.

*Нөөцөөр хангагчид*

ДҮ2.8. Нөөцөөр хангагчдын мэдээллийн хэрэгцээг хангахын тулд мэдээллийг бүрдүүлэхэд чиглэсэн НЗСТ нь тухайн НЗСТ-гийн бусад боломжит хэрэглэгчдэд ач холбогдолтой мэдээллийг бас бүрдүүлнэ гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрдөг. Гэвч засгийн газрууд ба улсын секторын бусад байгууллагууд нь тэднийг нөөцөөр хангадаг талууд болон шаардлагатай ба/буюу амласан үйлчилгээг үзүүлэхийн тулд тэдгээр нөөцийн ашиглалтаас хамааралтай байдаг талуудын аль алины өмнө хариуцлага хүлээвэл зохино гэсэн өөрийн хүлээлтийг Онолын үзэл баримтлалд тодорхой тусгах хэрэгтэй гэж УСНББОУСЗ үздэг. Мөн түүнчлэн, зарим улс оронд нөөцөөр хангагчид нь ихэвчлэн хандивлагчид буюу зээлдүүлэгчид байх бөгөөд өөрт шаардлагатай мэдээллийг бүрдүүлэхийн тулд тусгай зорилго бүхий санхүүгийн тайлан бэлтгэхийг шаардах бүрэн эрхтэй байж болно гэдгийг тэмдэглэсэн.

ДҮ2.9. ДҮ2.4-р параграфт дурдсанчлан, үйлчилгээ хүлээн авагчид, нөөцөөр хангагчид болон тэдний төлөөлөгчдийн аль аль нь НЗСТ-гийн үндсэн хэрэглэгчид гэсэн байр суурийг УСНББОУСЗ илэрхийлсэн. Үйлчилгээ хүлээн авагч болохын хувьд өөрийн бүрэн эрхийн хүрээнд НЗСТ-г сонирхож болох иргэдийг уг НЗСТ-гийн боломжит хэрэглэгчдээс хасахгүй



УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТой  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

буюу тэдний мэдээллийн хэрэгцээг нөөцөөр хангагчдын мэдээллийн хэрэгцээнээс арай бага ач холбогдолтой гэж Онолын үзэл баримтлалд тодорхойлохгүй байх хэрэгтэй гэсэн байр суурийг УСНББОУСЗ илэрхийлсэн. Мөн УСНББОУСЗ нь засгийн газрууд ба улсын секторын бусад байгууллагуудыг сайн дураар буюу сайн дурын бус байдлаар нөөцөөр хангадаг хандивлагчид, зээлдүүлэгчид болон бусад талуудыг НЗСТ-гийн боломжит хэрэглэгчдээс хасах, эсвэл тэдний мэдээллийн хэрэгцээг үйлчилгээ хүлээн авагчдын мэдээллийн хэрэгцээнээс арай бага ач холбогдолтой гэж тодорхойлох нь зохисгүй гэсэн байр суурьтай байсан.

*Хууль тогтоох байгууллага*

ДҮ2.10. Хууль тогтоох байгууллага буюу түүтэй адилтгах удирдах байгууллага нь үйлчилгээ хүлээн авагчид болон нөөцөөр хангагчдын төлөөлөгч болохын хувьд өөрийн бүрэн эрхийн хүрээнд НЗСТ-гийн үндсэн хэрэглэгч юм гэж УСНББОУСЗ үздэг. Хууль тогтоох байгууллага, парламент, зөвлөл ба адилтгах байгууллагууд нь өөрсдийн хариуцлагын болон шийдвэр гаргалтын тусгай зорилгын хувьд мэдээллийг бас шаардах бөгөөд тэрхүү мэдээллийг бүрдүүлэхийн тулд ихэвчлэн тусгай зорилготой илүү дэлгэрэнгүй санхүүгийн болон бусад тайлан бэлтгэхийг шаардах бүрэн эрхтэй байдаг. Гэвч тэд нөөцийг үр ашигтай ба зориулалтын дагуу ашигласан эсэх үнэлгээ болон тухайн засгийн газрын байгууллагууд, хөтөлбөр буюу үйл ажиллагаанд нөөцийг хуваарилах талаар шийдвэр гаргахдаа НЗСТ-гаар хангах мэдээлэл, түүнчлэн тусгай зорилготой санхүүгийн тайлангаар бүрдүүлэх мэдээллийг орц болгон бас ашиглаж болох юм.

ДҮ2.11. Засгийн газрын эсвэл сөрөг хүчний гишүүн эсэхээс үл хамааран хууль тогтоох байгууллагын болон бусад удирдах байгууллагын бие даасан гишүүд нь тухайн хууль тогтоох байгууллагаас эсвэл удирдах байгууллагаас чиглэл болгосон өөрийн албан үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг тусган толилуулахыг ихэвчлэн шаардаж чадах юм. Гэвч тэд өөр бусад зорилгод буюу өөр бусад нөхцөл байдалд шаардлагатай мэдээллээр хангах тийм санхүүгийн тайлан бэлтгэхийг шаардах бүрэн эрхгүй байж болно. Иймээс тэд үйлчилгээ хүлээн авагчид ба нөөцөөр хангагчид, өөрсдийн сонгогчид буюу тойргийн сонгогчдын төлөөлөгчдийн хувьд бүрэн эрхийн хүрээнд эсвэл иргэн ба нийгмийн гишүүний хувьд өөрийн хувийн бүрэн эрхийн хүрээнд НЗСТ-гийн хэрэглэгчид юм.

*Бусад хэрэглэгчийн бүлэг*

ДҮ2.12. Онолын үзэл баримтлалыг боловсруулах үедээ УСНББОУСЗ нь НЗСТ-гийн бусад боломжит янз бүрийн хэрэглэгчдийг, үүн дотроо тусгай сонирхолын бүлгүүд ба тэдний төлөөлөгчид, эсвэл улсын секторын байгууллагуудтай арилжааны болон арилжааны бус хэлбэрээр, эсвэл сайн дурын болон сайн дурын бус үндсэн дээр ажил гүйлгээ хийж буй талуудыг (улсын секторын ба хувийн секторын нөөцөөр хангагчид гэх мэт) хэрэглэгчдийн тусдаа бүлэг гэж тодорхойлох хэрэгтэй эсэхийг харгалзан үзсэн. Үйлчилгээ хүлээн

## УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

авагчид ба тэдний төлөөлөгчид, нөөцөөр хангагчид ба тэдний төлөөлөгчдийг НЗСТ-гийн үндсэн хэрэглэгчид гэж тодорхойлох нь тэдгээр үйлчилгээ хүлээн авагчид ба нөөцөөр хангагчдын дэд бүлгүүдийн мэдээллийн хэрэгцээг илүү зохистойгоор хангана гэж УСНББОУСЗ үзэж байна.

ДҮ2.13. НЗСТ-гаар хангах мэдээлэл нь санхүүгийн тайлагналын статистик загварын орц болохын хувьд үндэсний тооцоог бүрдүүлэхэд, эдийн засгийн үйл ажиллагаанд засгийн газрын бодлогын үзүүлэх үр нөлөөг үнэлэхэд болон эдийн засгийн шинжилгээний бусад зорилгод ач холбогдолтой байж болох юм. Гэвч өөрсдийн зорилгын хувьд мэдээллийг шаардах тэдгээр талуудын хэрэгцээ шаардлагад хариулт өгөхийн тулд НЗСТ-г тусгайлан бэлтгэдэггүй. Үүнтэй адилаар, үйлчилгээ хүлээн авагчид болон нөөцөөр хангагчдын зөвлөгчийн үүрэг гүйцэтгэж буй талууд (иргэдийг хамгаалах бүлэг, бондын зэрэглэл тогтоодог агентлаг, зээлийн шинжээч, олон нийтийн эрх ашгийн бүлэг) нь НЗСТ-д тусгасан мэдээллийг өөрсдийн зорилгод ач холбогдолтой гэж үзэх магадлалтай боловч тэдний тухайлсан мэдээллийн хэрэгцээг хангахын тулд НЗСТ-г тусгайлан бэлтгэдэггүй.

### **Санхүүгийн тайлагналын зорилтууд**

ДҮ2.14. Саналын Төсөлд хариулт өгсөн олон хүмүүс нь хариуцлагатай байдал ба шийдвэр гаргалтын зорилгын аль алины хувьд ач холбогдолтой мэдээллээр хангахыг улсын секторын байгууллагуудын санхүүгийн тайлагналын зорилт гэж тодорхойлох хэрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Зөвхөн хариуцлагатай байдлыг улсын секторын байгууллагуудын санхүүгийн тайлагналын цор ганц буюу гол зорилт гэж тодорхойлохыг хариулт өгсөн зарим хүмүүс дэмжиж байсан; хариулт өгсөн өөр зарим хүмүүс нь шийдвэр гаргалтыг цорын ганц зорилт гэж тодорхойлохыг дэмжсэн. Гэвч улсын секторын байгууллагуудын НЗСТ-гийн хэрэглэгчид нь хариуцлагатай байдал ба шийдвэр гаргалтын зорилгын аль алины хувьд мэдээллийг шаардана гэсэн байр сууриа УСНББОУСЗ хэвээр хадгалсан.

ДҮ2.15. Саналын Төсөлд хариулт өгсөн зарим хүмүүс нь хариуцлага ба шийдвэр гаргалтын хоорондох уялдаа холбоог илүү тодорхой болгож, улсын секторын байгууллагуудын санхүүгийн тайлагналын зорилтуудын талаархи УСНББОУСЗ-ийн үзэл санааны суурь үндэслэл болох улсын секторын шинж чанаруудыг нарийн тогтоохыг дэмжсэн. УСНББОУСЗ нь эдгээр саналд эерэг хариулт өгсөн. Үзэл баримтлалын бүтцийг дахин өөрчилж, тодруулах зүйлсийг нэмж оруулсан.

ДҮ2.16. Хариуцлагатай байдал, түүнчлэн шийдвэр гаргалт ба НЗСТ-тай түүний холбогдох харилцааг мөн улам тодотгож өгсөн. Энэ хүрээнд УСНББОУСЗ нь энэхүү Үзэл баримтлалд тусгасан хариуцлагатай байдлын талаархи ойлголт өргөн хүрээтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Энэ нь түүнд итгэмжлэн хариуцуулсан нөөцийн хувьд уг байгууллагын удирдлагын талаархи мэдээлэл, тухайн байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдал болон үйлчилгээг урт хугацаанд тасралтгүй үзүүлэх боломжийг үнэлэхэд хэрэглэгчдэд ач холбогдолтой мэдээллийн хангалтыг өөртөө агуулдаг.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Иргэд болон бусад сонгогчид нь засгийн газар ба улсын секторын бусад байгууллагуудыг сайн дурын бус байдлаар нөөцөөр хангадаг бөгөөд шаардлагатай үйлчилгээг урт хугацаанд үзүүлэх тэдгээр засгийн газар ба улсын секторын бусад байгууллагаас ихэнх тохиолдолд хамааралтай байдаг тул хариуцлагын энэхүү өргөн хүрээтэй ойлголт тохиромжтой гэж УСНББОУСЗ үзсэн. Гэвч НЗСТ нь хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд үйлчилгээ хүлээн авагчид болон нөөцөөр хангагчдад шаардлагатай бүх мэдээллээр хангах магадлал багатай гэдгийг УСНББОУСЗ мөн хүлээн зөвшөөрсөн.

**Санхүүгийн тайлагналын цар хүрээ - Санхүүгийн тайлан, түүнчлэн тухайн санхүүгийн тайланг бэхжүүлэн сайжруулах, нэмж гүйцээх, дэлгэрүүлэн баяжуулах мэдээлэл**

ДҮ2.17. Саналын Төсөлд хариулт өгсөн олон хүмүүс нь тодруулах шаардлагатай зарим асуудлуудыг тодорхойлохын хамтаар УСНББОУСЗ-өөс санал болгосон санхүүгийн тайлагналын цар хүрээ ба түүний тайлбарыг дэмжиж байгаагаа илэрхийлсэн, өөр зарим хүмүүс нь өргөн цар хүрээтэй асуудлыг авч үзсэн уг төслүүдийн хувьд шалгах боломжтой байдал, зэрэгцүүлэгдэх байдал гэх мэт чанарын шинжүүдийн хэрэглээний талаар заавар удирдамжаар хангах шаардлагатай гэдгийг онцлон тэмдэглэсэн. Бусад хүмүүс нь санхүүгийн тайлангаас өргөн хүрээтэй уг санхүүгийн тайлагналын цар хүрээг дэмжээгүй бөгөөд дараах зүйлсэд санаа зовж буйгаа илэрхийлсэн. Үүнд:

- Уг санал болгосон өргөн цар хүрээ нь тухайн үед хүчин төгөлдөр байсан УСНББОУСЗ-ийн Ажлын Даалгаварт тусгагдаагүй асуудлуудыг авч үзсэн;
- Санхүүгийн бус болон хэтийн мэдээлэл гэх мэт санхүүгийн тайланд хамаарахгүй асуудлуудын талаархи заавар удирдамж нь тухайн засгийн газар, удирдах байгууллага буюу бусад бүрэн эрх бүхий байгууллагын зохих ёсоор шийдвэрлэх асуудал юм;
- Саналын Төсөлд хариулт ирүүлсэн зарим хүмүүс нь уг цар хүрээ санхүүгийн тайланд хэт төвлөрсөн бөгөөд санхүүгийн бус мэдээлэл ба тогтвортой байдлын тайлагналын талаархи нэмэлт заавар удирдамжийг Онолын үзэл баримтлалд тусгасан гэдэгт санаа зовж буйгаа бас илэрхийлсэн.

ДҮ2.18. УСНББОУСЗ нь санхүүгийн тайланд хамруулан харуулснаас илүү дэлгэрэнгүй, санхүүгийн тайлагналын цар хүрээг Онолын үзэл баримтлалд тусган илэрхийлэх шаардлагатай гэсэн өөрийн байр суурийг хэвээр хадгалсан. Яагаад гэвэл:

- Засгийн газар ба улсын секторын бусад байгууллагуудын анхдагч зорилт нь ашиг олох бус, харин сонгогч иргэдэд үйлчилгээ үзүүлэх явдал юм;

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

- Иргэд болон шалгуур хангасан бусад оршин суугчид нь янз бүрийн үйлчилгээг урт хугацаанд тасралтгүй үзүүлэх тухайн засгийн газар ба улсын секторын бусад байгууллагуудаас хамааралтай байдаг. Тухайн тайлант үед засгийн газар ба улсын секторын бусад байгууллагуудаас хэрэгжүүлсэн үйл ажиллагаа болон гаргасан шийдвэр нь үйлчилгээ хүлээн авагчдын ирээдүйн хойч үеийнхэн, татвар төлөгчид ба нөөцөөр сайн дурын бус байдлаар хангагчдын ирээдүйн хойч үеийнхэнд мэдэгдэхүйц үр дагавартай байдаг;
- Ихэнх засгийн газар ба улсын секторын бусад байгууллагууд нь төсвийн үйл явцаар тогтоосон зарцуулалтын эрх мэдэл болон санхүүгийн хязгаарлалтын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг. Батлагдсан төсвийн хяналт үнэлгээний хэрэгжилт нь хууль тогтоох байгууллагын зүгээс хяналт тавих, иргэд болон тэдний сонгосон төлөөлөгчид нь төрийн удирдлагыг санхүүгийн хувьд хариуцлагатай байлгах үндсэн арга юм.

ДҮ2.19. Иймээс улсын секторын байгууллагуудын санхүүгийн болон үйлчилгээ үзүүлэх зорилтуудын хэрэгжилтийг тайлангийн өдрөөрх тэдний санхүүгийн байдал ба тухайн тайлант үеийн турш дахь санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний шалгалтаар зөвхөн хэсэгчлэн үнэлж чадах юм. Хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээг хангахын тулд Онолын үзэл баримтлал нь санхүүгийн тайланг илүү сайн үнэлэх ба түүний хүрээнд тусгах боломжийг хэрэглэгчдэд олгох мэдээллийг НЗСТ-д хамруулан харуулах боломжтой байвал зохино гэж УСНББОУСЗ үздэг. Тайлант үеийн туршид тухайн байгууллагын үйлчилгээ үзүүлэх зорилтуудын биелэлтийн талаархи санхүүгийн болон санхүүгийн бус мэдээлэл; батлагдсан төсөв, түүнчлэн нөөцийн бүрдүүлэлт ба ашиглалтыг удирдан зохицуулах хууль тогтоомж буюу бусад бүрэн эрхийн даган мөрдөлт; түүний ирээдүйн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа, зорилтууд, нөөцийн хэрэгцээний талаархи хэтийн санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг толилуулдаг тусдаа тайлангуудаар ийм мэдээллийг хүргэн танилцуулж болох юм; Зарим тохиолдолд, эдгээр асуудлуудын талаархи мэдээллийг санхүүгийн тайлангийн тодруулгад бас толилуулж болох юм.

ДҮ2.20. НЗСТ-д толилуулах мэдээллийг санхүүгийн тайлангаас илүү өргөжүүлэн дэлгэрүүлэх санхүүгийн тайлагналын шаардлагууд буюу заавар удирдамжийн талаар шийдвэр гаргах үедээ УСНББОУСЗ нь хэрэглэгчдэд тухайн мэдээллийн өгөх өгөөж ба ийм мэдээллийг эмхлэн бүрдүүлэх, тайлагнах өртөг зардлыг харгалзан үзнэ.

*Санхүүгийн тайлагналын цар хүрээг хязгаарлах*

ДҮ2.21. Санхүүгийн тайлагналын цар хүрээг тухайн санхүүгийн тайлангаас илүү өргөн хүрээтэй байхыг хүлээн зөвшөөрсөн, хариулт өгсөн зарим хүмүүс нь уг Саналын Төсөлд тусгасан цар хүрээ хэт нээлттэй ба/буюу зохих ёсоор тайлбарлаагүй, зөвтгөн батлаагүй байна гэж санаа зовж буйгаа илэрхийлсэн - санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн зүйлсийг бэхжүүлэн

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

сайжруулахын тулд зарим тохиолдолд цар хүрээг хязгаарлахыг санал болгож байсан.

ДҮ2.22. УСНББОУСЗ нь санхүүгийн тайлагналын цар хүрээ ба хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээний хоорондох уялдаа холбоог тодруулах, түүнчлэн хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээ ба хариулт болгон НЗСТ-д тусгаж болох мэдээллийн хоорондох харилцаа холбооны талаар нэмэлт тайлбар оруулснаар эдгээр санаа зовж буй зүйлсэд хариулт өгсөн. Мөн түүнчлэн, нийтлэг зорилготой санхүүгийн тайлагналын цар хүрээг тухайн санхүүгийн тайлан ба түүнийг бэхжүүлэн сайжруулах, нэмж гүйцээх, дэлгэрүүлэн баяжуулах мэдээллээр хязгаарлана гэдгийг УСНББОУСЗ тайлбарлан тодруулсан. Иймээс санхүүгийн тайлагналын илүү дэлгэрэнгүй цар хүрээнд хамруулах зүйлсийг тухайн санхүүгийн тайлангаас гарган бэлтгэх бөгөөд тэдгээр санхүүгийн тайланд тусгасан мэдээллийг илүү сайн ойлгох ба түүний хүрээнд хамруулан оруулахад хэрэглэгчдэд туслах асуудлуудаар хязгаарлагдана.

*Нөөцийн анхаарах зүйлс, Бүрэн эрхийн шаардлагууд ба Аудитын төлөв байдал*

ДҮ2.23. Саналын Төсөлд тусгасан саналуудыг дэмжсэн эсвэл эсэргүүцсэн эсэхээс үл хамааран хариулт өгсөн олон хүмүүс нь “өргөн хүрээтэй” асуудлуудыг авч үзсэнээр УСНББОУСЗ-ийн нөөцийг хэт их зарцуулж, санхүүгийн тайлангийн асуудлуудыг харгалзан шийдвэрлэх түүний чадвар боломж хязгаарлагдана гэдэгт санаа зовж буйгаа илэрхийлсэн. Саналын Төсөлд хариулт ирүүлсэн зарим хүмүүс нь мөн дараах зүйлсийг илэрхийлсэн:

- Санхүүгийн тайлангийн асуудлуудын хувьд бүрэн эрхэт шаардлагуудыг зөвхөн боловсруулан гаргана гэдгийг Онолын үзэл баримтлалд тодруулан заасан бөгөөд илүү өргөн цар хүрээний асуудлуудыг зааварт тусгана гэдгийг дэмжсэн;
- НЗСТ-д санхүүгийн бус мэдээлэл болон хэтийн мэдээллийг тусган оруулахын аудитын үр нөлөөний талаар санал сэтгэгдлээ илэрхийлсэн.

ДҮ2.24. УСНББОУСЗ нь бүрэн эрхэт шаардлагууд бүхий УСНББОУС-ыг боловсруулж болох боловч үүнийг гүйцэтгэх нь зайлшгүй шаардлагатай биш юм. Тухайлбал; санхүүгийн тайлагналын тодорхой асуудлуудад хариулт өгөхөд санхүүгийн тайлагналын нийт олон түмэнд туслахад зориулагдсан СБП болон бусад баримт бичгүүдийг УСНББОУСЗ-ийн хэвлэл бүтээлд тусгасан байдаг. Санхүүгийн тайлангийн нэг хэсэг болох эсвэл тэдгээр тайлангийн бэхжүүлэн сайжруулалт эсэхээс үл хамааран НЗСТ-д мэдээллийг толилуулах бүрэн эрхэт шаардлагууд буюу заавар удирдамжийг агуулсан УСНББОУСЗ-ийн бүх баримт бичгүүд нь албан үйл ажиллагаанд бүрэн хамрагдсан байдаг. Иймээс санхүүгийн тайлагналын цар хүрээг өргөжүүлдэг мэдээллийн толилуулгын талаархи бүрэн эрхэт буюу бусад заавар удирдамжийг боловсруулахдаа УСНББОУСЗ нь тухайн заавар удирдамжийн санал болгосон техникийн агуулга болон бүрэн эрхийн талаархи сонгогчдын санаа зовж буй зүйлсэд хариулт өгөх шаардлагатай байдаг.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

ДҮ2.25. УСНББОУС3-ийн нөөцийг илүү өргөн цар хүрээний асуудлуудад зарцуулж байгаа талаар хариулт өгсөн хүмүүс санаа зовж буйг УСНББОУС3 тэмдэглэсэн. Гэвч санхүүгийн тайланд толилуулсан мэдээлэл нь санхүүгийн тайлагналын гол цөм хэвээр үлдэх бөгөөд иймээс УСНББОУС3-ийн боловсруулсан УСНББОУС болон СБПУ-ийн үндсэн анхаарах асуудал хэвээр байна. Иймээс УСНББОУС3-ийн стандарт боловсруулах ажлын хөтөлбөр нь санхүүгийн тайланд тусгах ажил гүйлгээ болон бусад үйл явдлын илүү сайн санхүүгийн тайлагнал талаархи хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад хариулт өгсөн хэвээр байх болно.

ДҮ2.26. НЗСТ-гийн тодорхой төлөв байдлын талаар ханган бүрдүүлвэл зохих аудитын баталгаажуулалтын түвшин тогтоохоор эрмэлзэх нь Онолын үзэл баримтлалын, эсвэл түүнд тусгасан ойлголт ухагдахуунд нийцүүлэн боловсруулж болох УСНББОУС болон СБПУ-ийн үүрэг биш гэж УСНББОУС3 үздэг. Чанарын шинжүүд нь НЗСТ-д тусгасан мэдээллийн чанарын талаар хэрэглэгчдийг зарим баталгаагаар хангадаг. Гэвч санхүүгийн тайлан болон НЗСТ-гийн бусад бүрэлдэхүүн хэсгийн аудитын хувьд хүлээх хариуцлагыг тухайн улс орны зохицуулалтын үзэл баримтлал, уг байгууллагатай тохиролцсон ба/буюу түүнд мөрдөх аудитын бүрэн эрх гэх мэт асуудлуудаар тогтоодог.

## БҮЛЭГ 3: ЧАНАРЫН ШИНЖҮҮД

### АГУУЛГА

---

	Параграф
Танилцуулга	3.1-3.5
Хамааралтай байх	3.6-3.9
Үнэн зөв илэрхийлэх	3.10-3.16
Ойлгомжтой байх	3.17-3.18
Цаг хугацаандаа байх	3.19-3.20
Зэрэгцүүлэгдэх боломжтой байх	3.21-3.25
Шалгах боломжтой байх	3.26-3.31
Нийтлэг зорилготой санхүүгийн тайланд тусгасан мэдээллийн хязгаарлалтууд	3.32-3.42
Материаллаг байдал	3.32-3.34
Өртөг-өгөөж	3.35-3.40
Чанарын шинжүүдийн хоорондох тэнцвэр	3.41-3.42
Дүгнэлтийн үндэслэл	

---

## Танилцуулга

- 3.1 НЗСТ нь эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийн талаархи санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг толилуулдаг. НЗСТ-д тусган оруулсан мэдээллийн чанарын шинжүүд нь тухайн мэдээллийг хэрэглэгчдэд ач холбогдолтой болгох ба санхүүгийн тайлагналын зорилтуудын хэрэгжилтийг дэмжих шинжүүд юм. Санхүүгийн тайлагналын зорилтууд нь хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд ач холбогдолтой мэдээллээр хангах явдал юм.
- 3.2 Улсын секторын байгууллагуудын НЗСТ-д тусгах мэдээллийн чанарын шинжүүд нь хамааралтай байх, үнэн зөв илэрхийлэх, ойлгомжтой байх, цаг хугацаандаа байх, зэрэгцүүлэгдэх боломжтой байх, шалгах боломжтой байх гэсэн шинжүүд юм.
- 3.3 НЗСТ-д тусгасан мэдээллийн нийтлэг хязгаарлалтууд нь материаллаг байдал, өртөг-өгөөж бөгөөд энэ нь чанарын шинжүүдийн хоорондох зохих тэнцвэрийг тогтоодог.
- 3.4 Чанарын шинж бүр нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг биелүүлэхэд ач холбогдолтой НЗСТ-гийн мэдээллийн салшгүй хэсэг бөгөөд ийм мэдээллийг бүрдүүлэхэд бусад шинжүүдтэй хамтран үүрэг гүйцэтгэдэг. Гэвч практикт бүх чанарын шинжүүд бүрэн хангагдахгүй байж болох бөгөөд тэдгээрийн заримын хоорондох тэнцвэр буюу уялдааг хангах шаардлагатай байж болох юм.
- 3.5 НЗСТ-д тайлагнасан бүх санхүүгийн болон санхүүгийн бус мэдээлэлд, үүний дотор түүхэн ба хэтийн мэдээлэл, түүнчлэн тайлбар мэдээлэлд уг чанарын шинжүүдийг мөрддөг. Гэвч чанарын шинжүүдийг хангах хэмжээ нь санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг эмхлэн бүрдүүлэхтэй холбоотой тодорхой бус байдлын зэрэг хэмжээ, субъектив үнэлгээ буюу санал дүгнэлтээс хамааран өөр өөр байж болох юм. Санхүүгийн тайлагналын цар хүрээг тухайн санхүүгийн тайлангаас илүү өргөжүүлэх мэдээллийг тайлбарлах ба тэдгээрт чанарын шинжүүдийг мөрдөх талаархи нэмэлт заавар удирдамжийн хэрэгцээ шаардлагыг тэдгээр асуудлуудыг зохицуулдаг аливаа УСНББОУС болон СБПУ-ийг боловсруулах үедээ харгалзан үздэг.

## Хамааралтай байх

- 3.6 Санхүүгийн болон санхүүгийн бус мэдээлэл нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг биелүүлэхэд ялгаатай байдал үүсгэх чадвар боломжтой бол хамааралтай гэж үзнэ. Санхүүгийн болон санхүүгийн бус мэдээлэл нь баталгаажуулах үнэ цэнэтэй, урьдчилан таамаглаж болох үнэ цэнэтэй эсвэл уг үнэ цэнийн аль алиныг агуулсан тохиолдолд ялгаатай байдал үүсгэх боломжтой юм. Хэдийгээр зарим хэрэглэгчид нь ийм мэдээллийн давуу талыг ашиглахгүй байх сонголт хийсэн буюу түүнийг угаасаа мэддэг байж болох боловч энэ нь ялгаатай байдал үүсгэх, ингэснээр хамааралтай байх боломжтой юм.



УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

- 3.7 Санхүүгийн болон санхүүгийн бус мэдээлэл нь өмнөх (буюу одоогийн) хүлээлтийг баталгаажуулдаг эсвэл өөрчилдөг бол баталгаажуулах үнэ цэнэтэй байна. Жишээлбэл; мэдээлэл нь нөөцийг үр ашигтай ба үр дүнтэй ашиглах, үйлчилгээ үзүүлэх тусгайлан заасан зорилтуудыг хэрэгжүүлэх, холбогдох төсвийн, хууль тогтоомжийн болон бусад шаардлагуудыг даган мөрдөх үүрэг хариуцлагаа менежерүүд хэрхэн биелүүлж буй хэмжээ гэх мэт асуудлуудын талаархи хүлээлтийг баталгаажуулж байвал хариуцлага ба шийдвэр гаргалтын зорилгын хувьд хамааралтай байна.
- 3.8 НЗСТ нь байгууллагын ирээдүйн урьдчилан таамагласан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа, зорилтууд ба өртөг зардал, түүнчлэн ирээдүйд үйлчилгээ үзүүлэхэд хуваарилагдах зориулалт бүхий нөөцийн дүн ба эх үүсвэрийн талаархи мэдээллийг толилуулж болох юм. Ирээдүйд чиглэсэн ийм мэдээлэл нь урьдчилан таамаглах үнэ цэнэтэй бөгөөд хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд хамааралтай байдаг. Одоо байгаа буюу аль хэдийн гарч тохиолдсон эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийн тухай мэдээлэл нь мөн ирээдүйн талаархи хүлээлт бий болгоход туслах урьдчилан таамагласан үнэ цэнэтэй байж болно. Жишээлбэл; өмнөх хүлээлтийг баталгаажуулах эсвэл үгүйсгэх мэдээлэл нь ирээдүйд гарч тохиолдож болох санхүүгийн үр дүнгүүд болон үйлчилгээ үзүүлэлтийн үр нөлөөний талаархи хүлээлтийг дахин бататгаж эсвэл өөрчилж болох юм.
- 3.9 Мэдээллийн баталгаажуулах болон урьдчилан таамаглах үүргүүд нь харилцан холбоотой байдаг. Тухайлбал; байгууллагын нөөцүүд болон тэдгээр нөөцийн нэхэмжлэлүүдийн одоогийн түвшин, бүтцийн талаархи мэдээлэл нь тухайн тайлант үеийн турш дахь нөөцийн удирдлагын стратегийн үр дүнг баталгаажуулах, өөрчлөгдөж буй нөхцөл байдал болон ирээдүйн урьдчилан таамагласан үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ шаардлагад хариу өгөх уг байгууллагын чадвар, боломжийг урьдчилан таамаглахад хэрэглэгчдэд тусалдаг. Уг мэдээлэл нь ийм өөрчлөлтөнд хариу үзүүлэх тухайн байгууллагын чадвар боломжийн талаархи хэрэглэгчдийн өмнөх хүлээлт ба таамаглалыг баталгаажуулах буюу засварлан өөрчлөхөд тусалдаг. Энэ нь мөн НЗСТ-д тусгасан хэтийн санхүүгийн мэдээллийг баталгаажуулах буюу засварлан өөрчлөхөд тусална.

**Үнэн зөв илэрхийлэх**

- 3.10 Санхүүгийн тайлагналын хувьд ач холбогдолтой байхын тулд мэдээлэл нь өөрийн илэрхийлэхийг зорьж буй эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийн үнэн зөв илэрхийлэл байх ёстой. Тухайн юмс үзэгдлийн илэрхийлэлт нь иж бүрэн, төв голч, материаллаг алдаагүй байх тохиолдолд үнэн зөв илэрхийлэлд хүрдэг. Эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийг үнэн зөв илэрхийлдэг мэдээлэл нь суурь ажил гүйлгээ, бусад үйл явдал, үйл ажиллагаа буюу нөхцөл байдлын мөн чанарыг дүрслэн харуулдаг. Мөн чанар нь өөрийн хуулийн хэлбэртэй ямагт ижил байх албагүй юм.
- 3.11 НЗСТ-д толилуулсан мэдээлэл нь иж бүрэн, төв голч ба материаллаг алдаагүй эсэхийг практикт мэдэх буюу баталгаажуулах боломжгүй байж

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

болох юм. Гэвч мэдээлэл нь аль болох иж бүрэн, төв голч ба материаллаг алдаагүй байвал зохино.

- 3.12 Зарим мэдээллийг орхигдуулах нь эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийн толилуулгыг худал буюу будлиантай болгох, ингэснээр НЗСТ-гийн хэрэглэгчдэд ач холбогдолгүй болоход хүргэж болох юм. Жишээлбэл; НЗСТ дахь “үндсэн хөрөнгө” гэсэн зүйлийн иж бүрэн илэрхийлэл нь тухайн үндсэн хөрөнгийн нэгдсэн дүнгийн тоон үзүүлэлтийг, түүнчлэн тэрхүү хөрөнгийн ангийг үнэн зөв илэрхийлэхэд шаардлагатай бусад тоон болон хүүрнэсэн тайлбар мэдээллийн хамт агуулсан байна. Зарим тохиолдолд энэ нь үндсэн хөрөнгийн гол ангиуд, тэдгээрийн өмнөх ашиглалтанд нөлөөлсөн буюу ирээдүйн ашиглалтанд нөлөөлж болох хүчин зүйлс, тэдгээрийн тоон үзүүлэлтийг тодорхойлох суурь ба процесс гэх мэт асуудлуудын талаархи мэдээллийн толилуулгыг агуулсан байж болно. Үүнтэй адилаар, НЗСТ-д тусгасан үйлчилгээ үзүүлэх зорилтуудын хэрэгжилт ба үр дүнгийн тухай хэтийн санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг тэрхүү мэдээллийн суурь үндэслэл болох гол таамаглалууд, түүнчлэн түүний илэрхийлэл нь иж бүрэн бөгөөд хэрэглэгчдэд ач холбогдолтой гэдгийг ханган магадлахад шаардлагатай аливаа тайлбарын хамт толилуулах шаардлагатай болдог.
- 3.13 Санхүүгийн тайлагнал дахь төв голч илэрхийлэл нь аль нэг талыг барьж, туйлшраагүй байх явдал юм. Энэ нь санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийн сонголт, толилуулгыг урьдчилан тодорхойлсон тухайн нэг үр дүнг гаргах санаа зорилготойгоор хийхгүй тухайлбал, байгууллагын хариуцлагын биелэлт, гаргасан шийдвэр буюу шүүн тунгаалтын талаархи хэрэглэгчдийн үнэлгээнд тодорхой арга замаар нөлөөлөхгүй эсвэл тухайлсан төлөв байдалд хөндлөнгөөс нөлөөлөхгүй гэсэн утгатай байдаг.
- 3.14 Төв голч мэдээлэл нь өөрийн илэрхийлэхийг зорьж буй эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийг үнэн зөв толилуулдаг. Гэвч НЗСТ-д тусгасан мэдээлэл төв голч байхын тулд энэ нь зорилгогүй эсвэл төлөв байдалд нөлөөгүй мэдээлэл байна гэсэн үг биш юм. Хамааралтай байдал нь чанарын шинж бөгөөд түүний тодорхойлолтод зааснаар, хамааралтай мэдээлэл нь хэрэглэгчдийн үнэлгээ болон шийдвэрт нөлөө үзүүлэх чадвартай байна.
- 3.15 НЗСТ-д илэрхийлсэн эдийн засгийн болон бусад юмс үзэгдэл нь ерөнхийдөө тодорхой бус нөхцөл байдалд гарч тохиолддог. Иймээс НЗСТ-д тусгасан мэдээлэл нь удирдлагын шүүн тунгаалтыг нэгтгэн илэрхийлсэн тооцооллыг ихэвчлэн агуулсан байдаг. Эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийг үнэн зөв илэрхийлэхийн тулд тооцоолол нь зохих орц өгөгдөлд үндэслэх ёстой бөгөөд орц өгөгдөл бүр нь боломжит хамгийн сайн мэдээллийг тусгах ёстой. Тодорхой бус байдлыг авч үзэхдээ анхаарал болгоомжтой хандах шаардлагатай. Зарим тохиолдолд эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийг үнэн зөв илэрхийлэхийн тулд тухайн санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийн тодорхой бус байдлын түвшинг дэлгэрэнгүй тодруулах шаардлагатай байж болно.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

- 3.16 Материаллаг алдаагүй гэдэг нь бүх талаараа зөв, оновчтой байна гэсэн үг биш юм. Материаллаг алдаагүй байна гэдэг нь тухайн юмс үзэгдлийн тайлбар тодорхойлолтын хувьд дангаараа эсвэл нэгдсэн дүнгээрээ материаллаг хэмжээний алдаа буюу орхигдуулалтгүй бөгөөд уг тайлагнасан мэдээллийг бий болгоход ашигласан процессыг тайлбарлан тодорхойлсны дагуу хэрэгжүүлсэн байхыг хэлнэ. Зарим тохиолдолд НЗСТ-д тусгасан зарим мэдээллийн оновчтой байдлыг тодорхойлох боломжтой байж болох юм. Жишээлбэл; засгийн газрын өөр түвшинд шилжүүлсэн мөнгөний дүн, үзүүлсэн үйлчилгээний хэмжээ, үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн үнэ. Гэвч зарим тохиолдолд ийм боломжгүй байж болно. Жишээлбэл; тухайн зүйлийн үнэ цэнэ буюу өртгийн тооцооллын оновчтой байдал, үйлчилгээ үзүүлэх хөтөлбөрийн үр дүнтэй байдлыг тодорхойлох боломжгүй байж болох юм. Ийм тохиолдолд тухайн дүн нь тооцоолол гэдгийг ойлгомжтой тодорхойлсон, тооцоолох процессын шинж төрөл ба хязгаарлагдмал талыг тайлбарласан, тооцоолол хийх зохих процессыг сонгох болон хэрэглэхдээ алдаа гаргаагүй бол тэрхүү тооцооллын илэрхийлэл нь материаллаг алдаагүй байна.

**Ойлгомжтой байх**

- 3.17 Ойлгомжтой байдал нь түүний утгыг ойлгох боломжийг хэрэглэгчдэд олгодог мэдээллийн чанар юм. Улсын секторын байгууллагуудын НЗСТ нь хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага ба мэдлэгийн суурь, түүнчлэн толилуулах мэдээллийн шинж төрөлд тохирсон арга замаар мэдээллийг толилуулвал зохино. Жишээлбэл; санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийн тайлбар, тухайн тайлант үеийн турш дахь үйлчилгээ үзүүлэлтийн ба бусад зорилтын биелэлтийн талаархи санал тайлбар, ирээдүйн тайлант үеүдийн хүлээлтийг энгийн хэллэгээр бичиж, хэрэглэгчдэд шууд ойлгогдох тийм арга замаар толилуулвал зохино. Мэдээллийг ойлгомжтой, товч тодорхой ангилах, ялган тодорхойлох ба толилуулах нь түүний ойлгомжтой байдлыг нэмэгдүүлдэг. Зэрэгцүүлэгдэх байдал нь ойлгомжтой байдлыг бас нэмэгдүүлж чадах юм.
- 3.18 НЗСТ-гийн хэрэглэгчид нь байгууллагын үйл ажиллагаа болон түүний үйл ажиллагаа явуулдаг орчны талаар зохих мэдлэгтэй, НЗСТ-г уншиж ойлгох ба толилуулсан мэдээллийг зохих хянамгай байдлаар нягталж шалгах, шинжлэх чадвартай бөгөөд ийм чадвартай байхаар бэлтгэгдсэн хүмүүс байдаг гэж үздэг. Зарим эдийн засгийн болон бусад юмс үзэгдлүүд нь НЗСТ-д толилуулахад ихээхэн нарийн цогц, төвөгтэй бөгөөд зарим хэрэглэгчид нь тэдгээрийг ойлгоход туслуулах үүднээс зөвлөгчийн тусламжийг авах шаардлагатай байж болох юм. НЗСТ-д тусгасан эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийг янз бүрийн хэрэглэгчдэд ойлгомжтой байдлаар илэрхийлэхийн тулд бүх хүчин чармайлтыг гаргах хэрэгтэй. Гэвч зарим хэрэглэгчдийн хувьд туслалцаа авахгүйгээр ойлгоход хэт нарийн цогц буюу төвөгтэй байж болно гэдгээс зөвхөн шалтгаалан мэдээллийг НЗСТ-д тусгахгүй орхиж болохгүй юм.

### **Цаг хугацаандаа байх**

- 3.19 Цаг хугацаандаа байх гэдэг нь хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд ач холбогдолтой байх өөрийн чадвараа алдахаас өмнө мэдээллийг хэрэглэгчдэд бэлэн байлгахыг хэлнэ. Хамааралтай мэдээллийг нэн даруй бэлэн байлгах нь хариуцлагатай байдал, түүнчлэн гаргах шаардлагатай шийдвэрийг мэдээлэх ба шийдвэрт нөлөөлөх түүний чадварын үнэлгээний хувьд орц болох уг мэдээллийн ач холбогдолтой байдлыг нэмэгдүүлдэг. Цаг хугацаандаа бэлэн байхгүй нь мэдээллийг ач холбогдол багатай болгодог.
- 3.20 Мэдээллийн зарим хэсэг нь тайлант үе буюу тайлангийн өдрөөс хойш нилээд урт хугацаанд ач холбогдолтой хэвээр байж болно. Жишээлбэл; хариуцлагын ба шийдвэр гаргалтын зорилгын хувьд НЗСТ-гийн хэрэглэгчид нь тухайн байгууллагын санхүүгийн болон үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэлийн хандлага, түүнчлэн хэд хэдэн тайлант үеийн турш дахь түүний төсвийн нийцэлтийг үнэлэх шаардлагатай байж болох юм. Түүнчлэн, үйлчилгээ үзүүлэх зарим хөтөлбөрийн үр дүн ба үр нөлөөг ирээдүйн тодорхой тайлант үеүд хүртэл тодорхойлох боломжгүй байж болно – тухайлбал; сонгогч иргэдийн эдийн засгийн аж байдлыг дээшлүүлэх, тодорхой өвчний дэгдэлтийг бууруулах, зарим насны бүлгийн иргэдийн бичиг үсэгт тайлагдалтын түвшинг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөтөлбөрүүдийн хувьд ийм тохиолдол үүсэж болно.

### **Зэрэгцүүлэгдэх боломжтой байх**

- 3.21 Зэрэгцүүлэгдэх боломжтой байдал нь хоёр цогц үзэгдлийн хоорондох ижил төсөөтэй болон ялгаатай талуудыг тодорхойлох боломжийг хэрэглэгчдэд олгодог чанарын шинж юм. Зэрэгцүүлэгдэх боломжтой байдал нь бие даасан мэдээллийн зүйлийн шинж чанар бус, харин мэдээллийн хоёр буюу хэд хэдэн зүйлсийн хоорондох харилцааны шинж чанар юм.
- 3.22 Зэрэгцүүлэгдэх боломжтой байдал нь тууштай байдлаас ялгаатай юм. Тууштай байдал гэдэг нь тухайн байгууллагын өөр өөр тайлант үеүдэд эсвэл нэгээс олон байгууллагуудын нэг тайлант үед нэг ижил нягтлан бодох бүртгэлийн зарчмууд буюу бодлогууд ба тайлан бэлтгэх суурь ашиглахыг хэлнэ. Зэрэгцүүлэгдэх боломжтой байдал нь зорилго, харин тууштай байдал нь уг зорилгод хүрэхэд тусалдаг. Тодорхой ажил гүйлгээ буюу үйл явдлыг НЗСТ-д илүү сайн илэрхийлэхийн тулд тухайн байгууллагын мөрддөг нягтлан бодох бүртгэлийн зарчмууд буюу бодлогыг зарим тохиолдолд засварлан өөрчилж болох юм. Ийм тохиолдолд нэмэлт тодруулга буюу тайлбарыг оруулах нь зэрэгцүүлэгдэх боломжтой байдлын шинж чанаруудыг хангахад зайлшгүй шаардлагатай байж болох юм.
- 3.23 Зэрэгцүүлэгдэх боломжтой байдал нь нэгэн хэвийн байдлаас мөн ялгаатай юм. Зэрэгцүүлэгдэх боломжтой мэдээллийн хувьд адил зүйлс нь адил харагдах, өөр зүйлс нь өөр харагдах ёстой. Нэгэн хэвийн байдалд хэт ач холбогдол өгөх нь өөр зүйлсийг адил болгон харагдуулснаар зэрэгцүүлэгдэх боломжтой байдлыг бууруулдаг. Өөр зүйлсийг адил

## УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

харагдуулах нь адил зүйлсийг өөр болгож харагдуулахаас өөр ямар нэг байдлаар НЗСТ дахь мэдээллийн зэрэгцүүлэгдэх боломжтой байдлыг нэмэгдүүлэхгүй.

3.24 Байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, түүнчлэн батлагдсан төсөв ба холбогдох хууль тогтоомж буюу нөөцийн бүрдүүлэлт ба ашиглалтыг удирдан зохицуулах бусад бүрэн эрхтэй нийцэлт, үйлчилгээ үзүүлэх зорилтын хэрэгжилт болон байгууллагын ирээдүйн төлөвлөгөөний талаархи мэдээлэл нь хариуцлагын зорилгод зайлшгүй шаардлагатай бөгөөд шийдвэр гаргах зорилгын хувьд орц болох ач холбогдолтой байдаг. Ийм мэдээллийг тухайлбал, дараах зүйлстэй зэрэгцүүлэгдэх боломжтой байвал түүний ач холбогдлыг нэмэгдүүлдэг:

- Тухайн тайлант үед буюу тайлангийн өдрөөр өмнө толилуулсан, хэтийн санхүүгийн болон санхүүгийн бус мэдээлэл;
- Тухайн нэг байгууллагын өөр зарим тайлант үе буюу өөр зарим хугацааны агшны талаархи ижил төсөөтэй мэдээлэл;
- Бусад байгууллагуудын (жишээлбэл; өөр өөр улс оронд ижил төсөөтэй үйлчилгээ үзүүлдэг улсын секторын байгууллагуудын) талаархи тухайн нэг тайлант үеийн ижил төсөөтэй мэдээлэл.

3.25 Нягтлан бодох бүртгэлийн зарчим, бодлого, тайлан бэлтгэх суурийг хэтийн санхүүгийн болон санхүүгийн бус мэдээлэл ба гүйцэтгэлийн үр дүнд тууштай мөрдөх нь төсөвлөсөн ба гүйцэтгэлийн үр дүнгийн аливаа зэрэгцүүлэлтийн ач холбогдлыг нэмэгдүүлдэг. Бусад байгууллагуудтай хийсэн зэрэгцүүлэлт нь тухайн байгууллагын одоогийн гүйцэтгэлийн суурь үндэслэл болох хүчин зүйлсийн талаархи удирдлагын төсөөлөл буюу санал дүгнэлтийг тайлбарлахад арай бага ач холбогдолтой байж болох юм.

### **Шалгах боломжтой байх**

3.26 Шалгах боломжтой байдал нь өөрийн илэрхийлэн харуулахыг зорьж буй эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийг тухайн НЗСТ дахь мэдээлэл үнэн зөв илэрхийлсэн гэдгийг хэрэглэгчдэд батлан харуулахад тусалдаг мэдээллийн шинж чанар юм. НЗСТ-д тодруулсан тайлбар мэдээлэл, түүнчлэн хэтийн санхүүгийн болон санхүүгийн бус тоон шинжтэй мэдээллийн хувьд хэрэглэх үед энэхүү шинжийг илэрхийлэхийн тулд дэмжигдэх боломжтой байдал гэсэн хэллэгийг зарим тохиолдолд ашигладаг. Өөрөөр хэлбэл, энэ нь өөрийн илэрхийлэн харуулахыг зорьж буй эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийг тэрхүү тайлбар буюу хэтийн санхүүгийн болон санхүүгийн бус тоон шинжтэй мэдээлэл үнэн зөв илэрхийлсэн гэдгийг хэрэглэгчдэд батлан харуулахад тусалдаг мэдээллийн шинж чанар юм. Шалгах боломжтой байдал эсвэл дэмжигдэх боломжтой байдал гэж нэрлэсэн эсэхээс үл хамааран энэхүү шинж чанар нь зохих мэдлэгтэй, хараат бус өөр өөр ажиглагч нар тухайн илэрхийлэл үнэн зөв эсэх талаар бүрэн тохиролцоонд заавал хүрэх албагүй боловч дараах аль нэг байдлаар ерөнхий зөвшилцөлд хүрч чадна гэсэн утгатай байдаг:

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

- Тухайн мэдээлэл нь өөрийн илэрхийлэн харуулахыг зорьж буй эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийг материаллаг алдаагүй буюу гажуудуулан гуйвуулахгүй илэрхийлэх;
  - Хүлээн зөвшөөрөлт, хэмжилт буюу илэрхийллийн тохиромжтой аргыг материаллаг алдаагүй буюу гажуудуулан гуйвуулахгүй мөрдөх.
- 3.27 Шалгах боломжтой байхын тулд мэдээлэл нь зөвхөн ганц тооцоолол байх албагүй юм. Боломжит дүнгүүд болон холбогдох магадлалын мужуудыг мөн шалгах боломжтой байдаг.
- 3.28 Шалгалт нь шууд эсвэл шууд бус байж болно. Шууд шалгалтын хувьд (а) мөнгийг тоолох, (б) түргэн борлогдох үнэт цаас ба тэдгээрийн жишиг үнийг ажиглах, (в) өмнөх үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэлд нөлөөлөх гэж тодорхойлсон хүчин зүйлс нь одоо хэрэгжиж байгаа бөгөөд уг тогтоосон үр нөлөөний хамтаар ажиллаж буй эсэхийг баталгаажуулах гэх мэтээр дүн буюу бусад толилуулгыг өөрийг нь шалагадаг. Шууд бус шалгалтын хувьд тухайн нэг нягтлан бодох бүртгэлийн тогтсон журам буюу арга зүйг ашигласнаар гарц үр дүнг дахин тооцоолох ба орц өгөгдлийг шалгаснаар дүн буюу бусад толилуулгыг шалгадаг. Жишээлбэл; орц өгөгдлийг (тоо хэмжээ ба өртгийг) шалгах ба өртгийн хөдөлгөөний нэг ижил төсөөллийг (жишээлбэл; эхэлж авсныг эхэлж зарлагдах аргыг) ашигласнаар бараа материалын эцсийн үлдэгдлийг дахин тооцоолох замаар бараа материалын дансны үнийг шалгах.
- 3.29 Шалгах боломжтой байдлын (хэрэв энэхүү шинж чанарыг илэрхийлэхдээ дэмжигдэх боломжтой байдал гэсэн нэр томъёог ашигласан бол дэмжигдэх боломжтой байдлын) шинж нь үнэмлэхүй дүн биш байдаг - зарим мэдээлэл нь бусад мэдээлэлтэй харьцуулахад арай илүү эсвэл арай бага шалгах боломжтой байж болох юм. Гэвч НЗСТ-д тусгасан мэдээлэл нь шалгах илүү их боломжтой байх тусам тухайн мэдээлэл нь өөрийн илэрхийлэн харуулахыг зорьж буй эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийг үнэн зөв илэрхийлсэн гэдгийг хэрэглэгчдэд илүү сайн батлан харуулна.
- 3.30 Улсын секторын байгууллагуудын НЗСТ нь (а) тайлант үеийн туршид тухайн байгууллагын гүйцэтгэлд үзүүлэх гол үр нөлөө, (б) тайлант үеийн туршид хэрэгжүүлсэн үйлчилгээ үзүүлэх хөтөлбөрийн урьдчилан таамагласан ирээдүйн үр нөлөө буюу үр дүн, (в) хэтийн санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийн талаархи санхүүгийн ба бусад тоон шинжтэй мэдээлэл, тайлбарыг агуулсан байж болно. Ийм мэдээллийн бүх тоон шинжтэй толилуулга болон тайлбарын үнэн зөв байдлыг ирээдүйн тайлант үе хүртэл огт шалгах боломжгүй байж болох юм.
- 3.31 НЗСТ-д тусгасан хэтийн санхүүгийн болон санхүүгийн бус тоон шинжтэй мэдээлэл ба тайлбар нь өөрийн илэрхийлэн харуулахыг зорьж буй эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийг үнэн зөв илэрхийлсэн гэдгийг хэрэглэгчдэд батлан харуулахад туслахын тулд уг толилуулсан мэдээллийн суурь үндэслэл болох таамаглалууд, тэрхүү мэдээллийг эмхлэн бүрдүүлэхэд хэрэглэсэн арга зүй, илэрхийлсэн санал дүгнэлт буюу хийсэн тодруулгыг дэмжих хүчин зүйлс болон нөхцөл байдал нь ил тод

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

байвал зохино. Энэ нь тэдгээр төсөөлөл, мэдээллийг эмхлэн бүрдүүлэх арга, мэдээллийн хэмжилт, толилуулга, тайлбарын тохиромжтой байдлын талаар шүүн тунгаалт хийх боломжийг хэрэглэгчдэд олгодог.

**Нийтлэг зорилготой санхүүгийн тайланд тусгасан мэдээллийн хязгаарлалтууд**

**Материаллаг байдал**

- 3.32 Мэдээллийн орхигдуулалт буюу буруу илэрхийлэлт нь уг байгууллагын үүрэг хариуцлагын биелэлт болон тухайн тайлант үеийн хувьд бэлтгэсэн тэрхүү байгууллагын НЗСТ-д үндэслэн гаргах хэрэглэгчдийн шийдвэрт нөлөө үзүүлж чадахаар бол ийм мэдээллийг материаллаг гэж үзнэ. Материаллаг байдал нь байгууллага бүрийн тухайн нөхцөл байдалд харгалзан үзэж буй уг зүйлийн шинж төрөл ба дүнгийн аль алианаас хамаардаг. НЗСТ нь тухайн тайлант үеийн турш дахь үйлчилгээ үзүүлэх зорилтын хэрэгжилтийн талаархи тоон болон чанарын шинжтэй мэдээлэл, ирээдүйн үйлчилгээ үзүүлэлт ба санхүүгийн үр дүнгийн талаархи хүлээлтийг агуулсан байж болно. Иймээс тодорхой төрлийн мэдээлэл нь материал байх нийтлэг тоон босго шалгуурыг тусгайлан заах боломжгүй юм.
- 3.33 Материаллаг байдлын үнэлгээг тухайн байгууллагын үйл ажиллагаа явуулдаг хууль эрх зүй, бүтэц зохион байгуулалтын болон үйл ажиллагааны орчны хүрээнд, хэтийн санхүүгийн болон санхүүгийн бус мэдээлэл, тайлан бэлтгэгчдийн ирээдүйн талаархи мэдлэг, хүлээлтийг харгалзан хийдэг. Хууль тогтоомж, зохицуулалт буюу бусад бүрэн эрхийн нийцэлт эсвэл үл нийцэлтийн талаархи мэдээллийн тодруулга нь холбогдох аливаа дүнгээс үл хамааран түүний шинж төрлийн улмаас материаллаг байж болох юм. Эдгээр тохиолдолд тухайн зүйл материаллаг эсэхийг тодорхойлохын тулд өнгөрсөн эсвэл урьдчилан таамагласан ажил гүйлгээ, үйл явдлуудын шинж төрөл, хууль ёсны байдал, мэдрэмжит байдал ба үр дагавар, ийм ажил гүйлгээнд оролцсон талууд, ажил гүйлгээ үүсэхэд хүргэсэн нөхцөл байдлууд гэх мэт асуудлуудыг харгалзан үзнэ.
- 3.34 Материаллаг байдлыг НЗСТ-д тусгасан мэдээллийн хязгаарлалт гэж Онолын үзэл баримтлалд ангилсан байдаг. УСНББОУС болон СБПУ-ийг боловсруулахдаа УСНББОУСЗ нь нягтлан бодох бүртгэлийн тодорхой бодлогын мөрдөлтийн үр дагавар, тайлан бэлтгэх суурь, тухайн зүйл буюу мэдээллийн төрлийн материаллаг байдлыг харгалзан үздэг. Аливаа УСНББОУС-ын шаардлагуудын дагуу НЗСТ-г бэлтгэж буй байгууллага нь тухайлбал, нягтлан бодох бүртгэлийн тодорхой бодлогын мөрдөлт болон тухайн мэдээллийн зүйлийн тусдаа тодруулгын материаллаг байдлыг мөн харгалзаж үзнэ.

**Өртөг-өгөөж**

- 3.35 Санхүүгийн тайлагналын хувьд тодорхой өртөг зардал гардаг. Санхүүгийн тайлагналын өгөөж нь тэрхүү өртөг зардлыг зөвтгөн баталвал зохино.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

НЗСТ-д тусгасан мэдээллийн бүх өртөг зардал болон бүх үр өгөөжийг тодорхойлох ба/буюу тоогоор илэрхийлэх ихэвчлэн боломжгүй байдаг учраас мэдээллээр хангасны үр өгөөж нь холбогдох өртөг зардлыг зөвтгөн батлах эсэхийг үнэлэх нь ямагт шүүн тунгаалтын асуудал болдог.

- 3.36 Мэдээллээр хангах өртөг зардал нь мэдээллийг олж цуглуулах ба боловсруулах зардал, мэдээллийг шалгах ба/буюу түүнийг дэмжих таамаглалууд болон арга зүйг танилцуулах зардал, мэдээллийг түгээн дамжуулах зардлаас бүрддэг. Хэрэглэгчид нь шинжлэх ба тайлбарлахад зардал гаргадаг. Ач холбогдолтой мэдээллийн орхигдуулалт нь мөн зардал гаргадаг. Үүнд: хэрэглэгчид нь уг шаардлагатай мэдээллийг бусад эх сурвалжаас олж авах, түүнчлэн НЗСТ-гаар хангасан бүрэн бус мэдээг ашигласнаар гаргасан шийдвэрийн үр дүн болох зардал хамаарна.
- 3.37 Тайлан бэлтгэгчид нь НЗСТ-д мэдээллийг тусгахад ихэнх хүчин чармайлтаа гаргадаг. Гэвч үйлчилгээ хүлээн авагчид болон нөөцөөр хангагчид нь эдгээр хүчин чармайлтын өртөг зардлыг эцсийн дүндээ хариуцдаг – яагаад гэвэл үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа нь НЗСТ-д тусган оруулах мэдээллийг бэлтгэхэд нөөцийг дахин чиглүүлэн хуваарилдаг.
- 3.38 Хэрэглэгчид нь НЗСТ-гаар хангах мэдээллийн ихэнх үр өгөөжийг хүртдэг. Гэвч НЗСТ-д зориулж бэлтгэсэн мэдээллийг удирдлага нь мөн дотооддоо ашиглаж болох бөгөөд удирдлагын илүү сайн шийдвэр гаргалтанд хүргэдэг. Онолын үзэл баримтлал ба УСНББОУС-ууд, түүнчлэн тэдгээрт үндэслэсэн СБПУ-д тодорхойлсон ойлголт ухагдахуунд нийцүүлэн НЗСТ-д тусгасан мэдээллийн тодруулга нь санхүүгийн тайлагналын ил тод байдлын талаархи засгийн газрын болон улсын секторын бусад байгууллагуудын ойлголтыг сайжруулан бэхжүүлж, улсын секторын өрийн илүү оновчтой үнэ тогтоолтонд хувь нэмрээ оруулдаг. Иймээс улсын секторын байгууллагууд нь НЗСТ-гаар бэлтгэсэн мэдээллээс олон арга замаар бас өгөөж хүртэж болох юм.
- 3.39 Өртөг-өгөөжийн хязгаарлалтын хэрэглээ нь мэдээллийг тайлагнасны өгөөж тухайн мэдээллийг бэлтгэх ба ашиглахад гарах өртөг зардлыг зөвтгөн батлах магадлалтай эсэх үнэлгээг агуулсан байдаг. Ийм үнэлгээг хийх тохиолдолд өртөг зардлыг бууруулахын тулд нэг буюу хэд хэдэн чанарын шинжүүдийг тодорхой хэмжээгээр алдагдуулж болох эсэхийг харгалзан үзэх шаардлагатай байдаг.
- 3.40 УСНББОУС-ыг боловсруулахдаа, УСНББОУСЗ нь тухайн санал болгож буй шаардлагуудын үр өгөөж ба өртөг зардлын хүлээгдэж буй шинж төрөл, тоо хэмжээний талаар тайлан бэлтгэгчид, хэрэглэгчид, эрдэмтэн судлаачид болон бусад талуудаас хүлээн авсан мэдээллийг харгалзан үздэг. Тэдгээр тодруулга болон бусад шаардлагуудыг даган мөрдсөний үр өгөөж нь холбогдох өртөг зардлыг зөвтгөн батлана гэж УСНББОУСЗ-өөс үнэлсэн тохиолдолд хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд НЗСТ-гийн хэрэглэгчдэд ач холбогдолтой мэдээллийг толилуулахад хүргэх бөгөөд чанарын шинжүүдийг хангах тийм тодруулга ба бусад шаардлагуудыг УСНББОУС-д тодорхойлдог.



**Чанарын шинжүүдийн хоорондох тэнцвэр**

- 3.41 Чанарын шинжүүд нь мэдээллийн ач холбогдолтой байдалд хувь нэмрээ оруулахын тулд хамтран ажилладаг. Жишээлбэл; хамааралгүй юмс үзэгдлийн үнэн зөв илэрхийлэл ба хамааралтай юмс үзэгдлийн буруу илэрхийллийн аль аль нь ач холбогдолтой мэдээллийг бий болгохгүй. Үүнтэй адилаар хамааралтай байхын тулд мэдээлэл нь цаг хугацаандаа, ойлгомжтой байх ёстой.
- 3.42 Зарим тохиолдолд чанарын шинжүүдийн хоорондох тэнцвэр буюу уялдаа нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг хангахад зайлшгүй шаардлагатай байж болох юм. Нөхцөл байдал тус бүр дэх чанарын шинжүүдийн харьцангуй ач холбогдол нь мэргэжлийн шүүн тунгаалтын асуудал юм. Зорилго нь тухайн санхүүгийн тайлагналын зорилтуудыг хангахын тулд чанарын шинжүүдийн хоорондох зохистой тэнцвэрт хүрэх явдал юм.

## **Дүгнэлтийн үндэслэл**

*Энэхүү Дүгнэлтийн үндэслэл нь Онолын үзэл баримтлалыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### **Нийтлэг зорилготой санхүүгийн тайланд тусгасан мэдээллийн чанарын шинжүүд**

- ДҮЗ.1. УСНББОУС-ыг боловсруулахдаа, УСНББОУСЗ нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг хамгийн сайн хангах ба НЗСТ-д тусгавал зохих мэдээллийн талаар иргэд сонгогчдын санал хүсэлтийг хүлээн авч, уг мэдээллийн хувьд шүүн тунгаалт хийдэг. Ийм шүүн тунгаалт хийхдээ УСНББОУСЗ нь чанарын шинж бүрийг ханган биелүүлэх хэмжээг харгалзан үздэг. Тодруулгын болон бусад шаардлагуудыг мөрдсөний үр дүн болох мэдээлэл нь Онолын үзэл баримтлалд заасан чанарын шинжүүд ба өртөг-өгөөжийн хязгаарлалтыг хангана гэж үзсэн зөвхөн тийм тохиолдолд тэдгээр тодруулгын болон бусад шаардлагуудыг УСНББОУС-д тусгадаг.
- ДҮЗ.2. Саналын төсөлд хариулт ирүүлсэн зарим хүмүүс нь НЗСТ-д толилуулж болох бүх асуудалд, ялангуяа санхүүгийн тайланд хамаарахгүй илтгэл тайланд толилуулж болох тийм асуудалд чанарын шинжүүдийг мөрдөх талаар санаа зовж буйгаа илэрхийлсэн. УСНББОУСЗ нь энэхүү санаа зовж буй асуудлыг ойлгосон. Санхүүгийн тайланд хамаарахгүй мэдээллийн НЗСТ дахь толилуулгыг зохицуулдаг УСНББОУС ба СБПУ нь тэдгээр авч үзэж буй асуудлуудад чанарын шинжүүдийг мөрдөх талаархи нэмэлт заавар удирдамж тусган оруулахыг шаардаж болох юм гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн.
- ДҮЗ.3. УСНББОУСЗ-өөс гаргасан УСНББОУС ба СБПУ нь НЗСТ-д тусгаж болох санхүүгийн болон санхүүгийн бус бүх мэдээллийг авч үздэггүй. Тухайн тодорхой эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийг зохицуулах УСНББОУС эсвэл СБПУ байхгүй тохиолдол уг мэдээллийн зүйл нь Онолын үзэл баримтлалд тодорхойлсон чанарын шинжүүд болон хязгаарлалтуудыг хангах эсэх, ингэснээр НЗСТ-д тусгах шалгуурыг биелүүлэх эсэхийг тэрхүү НЗСТ-г бэлтгэж буй хүмүүс үнэлнэ. Санхүүгийн тайлагналын зорилтуудыг биелүүлэх хүрээнд ийм үнэлгээг хийх бөгөөд эргээд хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээ шаардлагыг хангахын тулд үнэлгээг гаргадаг.
- ДҮЗ.4. Зохих ёсоор төлөвлөн зохиомжилсон ба үр дүнтэйгээр ажилладаг нягтлан бодох бүртгэлийн систем болон процессыг ажиллуулах нь санхүүгийн тайлагналыг дэмжих нотолгоог цуглуулж, боловсруулах боломжийг удирдлагад олгодог. Ийм систем болон процессын шинж чанар нь НЗСТ-д тухайн байгууллагын тусган оруулах санхүүгийн мэдээллийн чанарыг баталгаажуулах гол хүчин зүйл юм.

### **Харгалзан үзэх бусад чанарын шинжүүд**

- ДҮЗ.5. Саналын Төсөлд хариулт ирүүлсэн зарим хүмүүс нь чанарын нэмэлт шинжүүдийг тодорхойлох хэрэгтэй гэсэн байр суурийг илэрхийлсэн. Эдгээр

## УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

нэмэлт чанарын шинжүүдэд “чин үнэнч”, “үнэн ба шударга байдал”, “найдвартай байдал”, “ил тод”, “тогтмол байдал” хамаарна.

ДҮЗ.6. Санхүүгийн тайлагналд ашигласан “чин үнэнч” гэдэг нь “үнэн ба шударга байдал”-тай ижил утгатай гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Чин үнэнч, үнэн ба шударга байдал, найдвартай байдал, ил тод байдал нь санхүүгийн тайлагналын хүрэх буюу эрмэлзэж буй нийтлэг чанаруудын чухал илэрхийлэл юм. Гэвч эдгээр нь өөрийн дан ганц чанарын шинж байдлаар оршин байдаггүй. Харин эдгээр чанаруудын биелэл нь Онолын үзэл баримтлал, түүнчлэн тайлагналын тухайн тодорхой асуудлуудыг зохицуулдаг УСНББОУС-уудад тодорхойлсон бүрэн цогц чанарын шинжүүдийн мөрдөлтийн үр дүн байдаг. Хэдийгээр НЗСТ-гийн чухал шинжүүд боловч тэдний бүрэн эрхийн хүрээнд тэдгээрийг тусдаа бие даасан чанарын шинжүүд гэж тодорхойлдоггүй. Хариулт өгсөн зарим хүмүүсийн тэмдэглэсэнчлэн, “тогтмол байдал” гэсэн ойлголт нь Онолын үзэл баримтлалд ашигласан “нийцэлт” гэсэн ойлголттой холбоотой, иймээс тогтмол байдлыг чанарын нэмэлт шинж байдлаар тодорхойлохгүй гэж УСНББОУСЗ бас дүгнэсэн.

### **Хамааралтай байх**

ДҮЗ.7. Санхүүгийн болон санхүүгийн бус мэдээлэл нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг хангахад ялгаатай байдал үүсгэх чадвартай бол тэдгээр нь хамааралтай мэдээлэл болно гэж Онолын үзэл баримтлалд тайлбарласан. Санал болгосон УСНББОУС буюу санал болгосон аливаа СБПУ-ийн шаардлагууд нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг биелүүлэхэд хамааралтай, өөрөөр хэлбэл хариуцлагатай байдал болон хэрэглэгчдийн гаргаж болох шийдвэрийн хувьд уг байгууллага үүргээ биелүүлэхэд хамааралтай эсэх талаархи саналыг УСНББОУСЗ нь өөрийн албан үйл ажиллагааны нэг хэсэг байдлаар авахыг хүссэн.

### **Үнэн зөв илэрхийлэх**

ДҮЗ.8. Ач холбогдолтой байхын тулд мэдээлэл нь өөрийн илэрхийлэхийг зорьж буй эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийн үнэн зөв илэрхийлэл байх ёстой гэж Онолын үзэл баримтлалд тайлбарласан. Нэг эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийг олон арга замаар үнэн зөв илэрхийлж болно. Жишээлбэл; тодорхой үйлчилгээ үзүүлэх зорилтуудын биелэлтийг (а) тухайн үйлчилгээг үзүүлэх хөтөлбөрийн ойрын болон урьдчилан таамагласан арай урт хугацааны үр дүн ба үр нөлөөг тайлбарлах замаар чанарын хувьд, (б) тухайн үйлчилгээг үзүүлэх хөтөлбөрийн дагуу үзүүлсэн үйлчилгээний тоо хэмжээ ба өртгийн хэмжүүр байдлаар тоон утгын хувьд, эсвэл (в) чанарын ба тоон мэдээллийн аль алиныг хослуулан харуулж болно. Мөн түүнчлэн, НЗСТ дахь нэг үзүүлэлт нь эдийн засгийн хэд хэдэн үзэгдлийг илэрхийлж болно. Жишээлбэл; санхүүгийн тайлан дахь “үндсэн хөрөнгө” гэсэн нэг зүйлийн толилуулга нь тухайн байгууллагын бүх үндсэн хөрөнгийн нэгдсэн дүнг, үүн дотроо янз бүрийн чиг үүрэгтэй, өөр өөр эрсдэл ба боломжтой, түүнчлэн нарийн цогц ба найдвартай байдлын хувьд арай

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

илүү эсвэл арай бага байж болох тийм тооцоололд үндэслэсэн дүнгээр бүртгэсэн зүйлсийг илэрхийлж болох юм.

ДҮЗ.9. Тооцооллын (болон тухайн тооцооллын орц өгөгдлийн) иж бүрэн, төв голч ба материаллаг алдаагүй байдал нь ач холбогдолтой бөгөөд эдийн засгийн буюу бусад юмс үзэгдлийг үнэн зөв илэрхийлэхийн тулд тооцооллын хувьд оновчтой байдлын зарим наад захын түвшин зайлшгүй шаардлагатай байдаг. Гэвч үнэн зөв илэрхийлэл нь тухайн тооцоолол туйлын иж бүрэн буюу төв голч гэсэн утгыг илэрхийлэхгүй, мөн түүний үр дүн огт алдаагүй гэсэн утгыг ч илэрхийлэхгүй юм. Эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийн толилуулгын хувьд хүрэх боломжгүй иж бүрэн, төв голч, алдаагүй байдлын түвшин нь уг мэдээлэл өөрийн илэрхийлэхийг зорьж буй эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийг үнэн зөв илэрхийлэх хэмжээг бууруулдаг.

*Үнэн зөв илэрхийлэл эсвэл найдвартай байдал*

ДҮЗ.10. Саналын Төслийг гаргаж байх үед УСНББОУС 1, *Санхүүгийн Тайлангийн Толилуулга*-ын Хавсралт А-д “найджартай байдал”-ыг чанарын шинж гэж тодорхойлж байсан. Энд найдвартай мэдээллийг “материаллаг алдаа ба туйлшралаас ангид байх бөгөөд өөрийн илэрхийлэхээр зориулагдсан буюу илэрхийлнэ гэж ул үндэслэлтэйгээр хүлээж болох зүйлсийг үнэн зөв илэрхийлэхдээ хэрэглэгчдээс хамаардаг байж болох” мэдээлэл гэж тодорхойлсон. Үнэн зөв илэрхийлэл, хэлбэрээс илүү мөн чанар, төв голч, хянамгай байдал, иж бүрэн байдал гэсэн шинжүүдийг найдвартай байдлын бүрэлдэхүүн хэсгүүд гэж тодорхойлсон. Онолын үзэл баримтлалд “найджартай байдал” гэсэн нэр томъёог биш, харин “үнэн зөв илэрхийлэл” нэр томъёог ашигладаг бөгөөд эдгээр нь үндсэндээ нэг ижил ойлголт ухагдахууныг илэрхийлдэг. Мөн түүнчлэн, хэлбэрээс илүү мөн чанар, хянамгай байдал гэсэн нэр томъёог үнэн зөв илэрхийллийн бүрэлдэхүүн хэсэг байдлаар Онолын үзэл баримтлалд дэлгэрэнгүй тодорхойлоогүй.

ДҮЗ.11. Саналын Төсөлд хариулт өгсөн олон хүмүүс нь уг Саналын Төсөл дэх үнэн зөв илэрхийлэл ба түүний тайлбарыг ашиглахыг дэмжсэн бөгөөд үнэн зөв илэрхийлэл нь тухайн зорьж буй ойлголт ухагдахууны мөн чанарыг илүү сайн дүрслэн илэрхийлнэ гэж зарим тохиолдолд тайлбарлаж байсан. Хариулт өгсөн өөр зарим хүмүүс нь найдвартай байдал гэдгийг үнэн зөв илэрхийлэл гэсэн нэр томъёогоор сольж орлуулахыг дэмжээгүй бөгөөд үнэн зөв илэрхийлэл гэдэг нь бодит үнэ цэнийн буюу зах зээлийн үнэ цэнийн нягтлан бодох бүртгэл мөрдөх гэсэн утгатай болно, найдвартай байдал ба үнэн зөв илэрхийлэл нь харилцан орлуулж болох нэр томъёо биш гэх мэт саналыг илэрхийлж байсан.

ДҮЗ.12. Онолын үзэл баримтлал дахь энэхүү чанарын шинжийг тодорхойлохын тулд уг асуудлын хувьд “үнэн зөв илэрхийлэл” эсвэл “найджартай байдал” гэсэн нэр томъёог ашиглах нь түүхэн өртөг, зах зээлийн үнэ цэнэ, бодит үнэ цэнэ болон хэмжилтийн бусад суурь гэх мэт НЗСТ-д мөрдөх хэмжилтийн суурийг тодорхойлон илэрхийлэхгүй юм. УСНББОУСЗ нь үнэн зөв илэрхийлэл нэр томъёоны хэрэглээг ийм байдлаар тайлбарлах санаа зорилгогүй байдаг. Санхүүгийн тайлангийн элементүүдийн хувьд мөрдөж

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

болох хэмжилтийн суурь буюу сууриудыг Бүлэг 7, *Санхүүгийн Тайлан дахь Хөрөнгө, Өр Төлбөрийн Хэмжилт*-д авч үзсэн. Иймээс чанарын шинжүүд нь НЗСТ-д тусгасан хэмжилтийн суурь буюу сууриудыг тухайн санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлсэн эсэхийг ханган магадлах үүрэг гүйцэтгэдэг.

ДҮЗ.13. Өөр нэр томъёо ашиглах нь найдвартай байдал нэр томъёогоор хүргэн танилцуулах чанарын шинжээс ялгаатай, түүнчлэн арай сул чанарын шинжийг тусган илэрхийлнэ гэж тайлбарлаж болох юм гэдэгт зарим хүмүүс санаа зовж буйг УСНББОУСЗ ойлгож, хүлээн зөвшөөрсөн. Гэвч “тухайн юмс үзэгдлийн илэрхийлэлт нь иж бүрэн, төв голч, материаллаг алдаагүй байх тохиолдолд үнэн зөв илэрхийлэлд хүрдэг” гэсэн Үзэл баримтлалын тайлбар ба эдгээр гол шинжүүдийн сайжруулан боловсруулалт нь найдвартай байдал нэр томъёонд өмнө нь тусгаж байсан аливаа чанарын шинжүүд алдагдахаас сэргийлнэ гэж УСНББОУСЗ үзсэн.

ДҮЗ.14. Мөн түүнчлэн, “найдартай байдал” нэр томъёо нь өөрөө янз бүрээр тайлбарлаж, шүүн тунгаалт хийж болох өргөн утгатай бөгөөд ингэснээр НЗСТ-д тусгасан мэдээллийн чанарт нөлөө үзүүлнэ гэдгийг УСНББОУСЗ-д мэдэгдсэн. “Үнэн зөв илэрхийлэл” нэр томъёог ашиглах нь найдвартай байдал нэр томъёогоор илэрхийлэх чанарын шинжүүдийг сулруулахгүй бөгөөд зарим улс оронд тулгарч буй уг нэр томъёоны тайлбар ба хэрэглээний асуудлуудыг шийдвэрлэж, олон хэлээр шууд орчуулж, ойлгох боломжтой болно гэж УСНББОУСЗ үзэж байна.

*Хэлбэрээс илүү мөн чанар ба хянамгай байдал*

ДҮЗ.15. Саналын Төсөлд хариулт өгсөн зарим хүмүүс нь хэлбэрээс илүү мөн чанар ба хянамгай байдлыг чанарын шинжүүд гэж тодорхойлоогүй буюу тэдгээрийн ач холбогдлыг хангалттай хүлээн зөвшөөрч, тайлбарлаагүй байгаад санаа зовж буйгаа илэрхийлсэн. Хянамгай байдал нь төв голч ба үнэн зөв илэрхийлэлд хүрэхэд харшлахгүй гэдгийг зарим хүмүүс бас тэмдэглэсэн.

ДҮЗ.16. “Эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийг үнэн зөв илэрхийлдэг мэдээлэл нь суурь ажил гүйлгээ, бусад үйл явдал, үйл ажиллагаа буюу нөхцөл байдлын мөн чанарыг дүрслэн харуулдаг бөгөөд мөн чанар нь өөрийн хуулийн хэлбэртэй ямагт ижил байх албагүй” гэж Онолын үзэл баримтлалд тайлбарласан. Иймээс хэлбэрээс илүү мөн чанар нь НЗСТ-д тусгасан мэдээллийн агуулах ёстой гол чанарын шинж хэвээр үлдэнэ. Энэ нь үнэн зөв илэрхийлэл гэсэн ойлголтонд угаасаа агуулагдах учраас түүнийг тусдаа эсвэл нэмэлт чанарын шинж байдлаар тодорхойлдоггүй.

ДҮЗ.17. УСНББОУСЗ нь үнэн зөв илэрхийллийн бүрэлдэхүүн хэсэг болох төв голч байдлын тайлбарт хянамгай байх гэсэн ойлголтыг мөн тусгасан бөгөөд тодорхойгүй нөхцөл байдлыг шийдвэрлэхдээ анхаарал болгоомжтой хандах хэрэгтэй гэдгийг мэдэгдсэн. НЗСТ-д тусгасан мэдээллийг тодорхойлоход хянамгай байдлын үзүүлэх үр нөлөө болон түүний санаа зорилго нь үнэн зөв илэрхийлэл гэсэн ойлголтонд аль хэдийн багтаж

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

агуулагдсан учраас хэлбэрээс илүү мөн чанар гэдэг шинжтэй адилаар хянамгай байдлыг тусдаа чанарын шинж гэж тодорхойлоогүй.

### **Ойлгомжтой байх**

ДҮЗ.18. Мэдээллийг товч, тодорхой толилуулах нь түүнийг ойлгоход хэрэглэгчдэд тусалдаг боловч мэдээллийн бодит хүлээн авалт буюу ойлголт нь НЗСТ-гийн хэрэглэгчдээс ихээхэн хамаардаг.

ДҮЗ.19. Зарим эдийн засгийн болон бусад юмс үзэгдэл нь НЗСТ-д илэрхийлэхэд ихээхэн нарийн цогц ба төвөгтэй байдаг. Гэвч тухайлбал, хамааралтай ба өөрийн илэрхийлэхийг зорьж буй зүйлийн үнэн зөв илэрхийлэл болох, цаг хугацаандаа бөгөөд шалгах боломжтой мэдээлэл нь зарим хэрэглэгчдийн хувьд бусдын тусалцаагүйгээр ойлгоход хэт нарийн цогц буюу төвөгтэй байж болно гэсэн шалтгаанаар түүнийг НЗСТ-д тусгахгүй орхигдуулж болохгүй гэж УСНББОУСЗ үздэг. НЗСТ-д толилуулсан мэдээллийг ойлгохын тулд зарим хэрэглэгчдэд тусламж шаардлагатай байж болно гэдгийг хүлээн зөвшөөрөх нь НЗСТ-д тусгасан мэдээлэл ойлгомжтой байх албагүй буюу мэдээллийг өргөн хүрээтэй хэрэглэгчдэд ойлгомжтой байдлаар НЗСТ-д толилуулах үүднээс бүх хүчин чармайлтаа гаргах хэрэггүй гэсэн үг биш юм. Гэвч практикт НЗСТ-д тусгасан мэдээлэл нь дурын хугацаанд хэрэглэгч нэг бүрийн хувьд чанарын бүх шинжүүдийг бүрэн хангахгүй байж болох тийм шинж чанартай гэдгийг энэ нь илэрхийлж байна.

### **Цаг хугацаандаа байх**

ДҮЗ.20. Цаг хугацаанд нь тайлагнаснаар хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын аль алины хувьд НЗСТ-гийн ач холбогдолтой байдлыг нэмэгдүүлнэ, харин мэдээллээр хангалтыг үндэслэлгүйгээр хойшлуулах нь эдгээр зорилгын хувьд түүний ач холбогдлыг бууруулна гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрдөг. Иймээс цаг хугацаандаа байхыг чанарын шинж гэж Онолын үзэл баримтлалд тодорхойлдог.

### **Зэрэгцүүлэгдэх боломжтой байх**

ДҮЗ.21. Хамааралтай ба үнэн зөв илэрхийлэл гэсэн чанарын шинжүүдийг хамгийн их болгосноор зэрэгцүүлэгдэх боломжтой байдлын тодорхой түвшинд хүрч болох юм. Жишээлбэл; нэг улсын секторын байгууллагын хамааралтай эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийн үнэн зөв илэрхийлэл нь нөгөө улсын секторын байгууллагын үүнтэй ижил төсөөтэй, хамааралтай эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийн үнэн зөв илэрхийлэлтэй зэрэгцүүлэгдэх боломжтой байх магадлалтай юм. Гэвч нэг эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийг ихэвчлэн хэд хэдэн арга замаар үнэн зөв илэрхийлж болох бөгөөд тухайн нэг юмс үзэгдлийн хувьд нягтлан бодох бүртгэлийн сонголтот өөр аргуудыг хэрэглэх нь зэрэгцүүлэгдэх боломжтой байдлыг багасгаж, ингэснээр тохиромжгүй болгож болох юм.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

ДҮ3.22. Зэрэгцүүлэгдэх боломжтой байдал ба тууштай байдлын хоорондох харилцан хамаарлын тайлбар нь санхүүгийн тайлагналын цаашдын хөгжилд саад учруулж байгаа мэтээр ойлгогдож болох юм гэдэгт санаа зовж буйгаа Саналын Төсөлд хариулт ирүүлсэн зарим хүмүүс илэрхийлсэн. Яагаад гэвэл, санхүүгийн тайлагналын сайжруулалт нь тухайн байгууллагын одоо мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн зарчим, бодлого буюу тайлан бэлтгэх суурийн хянан засварлалт болон өөрчлөлтийг ямагт агуулж байдаг.

ДҮ3.23. Тухайн нэг нягтлан бодох бүртгэлийн зарчим, бодлого, тайлан бэлтгэх суурийг нэг тайлант үеэс дараагийн тайлант үед тууштай мөрдөх нь уг байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, үйлчилгээ үзүүлэх зорилтын хэрэгжилтийг өмнөх тайлант үеүдтэй зэрэгцүүлснээр үнэлэхэд хэрэглэгчдэд тусалдаг. Гэвч тухайн тодорхой ажил гүйлгээ буюу бусад үйл явдлыг зохицуулах нягтлан бодох бүртгэлийн зарчмууд болон бодлогуудыг УСНББОУС-д тусгайлан заагаагүй тохиолдолд тэдгээр ажил гүйлгээ ба үйл явдлыг илүү сайн илэрхийлэхийн тулд өөрийн нягтлан бодох бүртгэлийн зарчим буюу бодлогоо өөрчлөхийг уг байгууллагад хориглосноор зэрэгцүүлэгдэх боломжит байдлын чанарын шинжийн биелэлтийг тайлбарлах нь зохисгүй юм. Энэ тохиолдолд уг өөрчилсөн бодлогын үр нөлөөний нэмэлт тодруулга буюу тайлбарыг НЗСТ-д тусган оруулснаар зэрэгцүүлэгдэх боломжит байдлын чанарын шинжийг хангасан хэвээр байж болно.

### **Шалгах боломжтой байх**

ДҮ3.24. Шалгах боломжтой байдал нь өөрийн илэрхийлэн харуулахыг зорьж буй эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийг тухайн НЗСТ дахь мэдээлэл үнэн зөв илэрхийлсэн гэдгийг хэрэглэгчдэд батлан харуулахад тусалдаг мэдээллийн шинж чанар юм. Үнэн зөв илэрхийлэлтэй нягт холбоотой боловч шалгах боломжтой байдлыг тусдаа чанарын шинж гэж тодорхойлдог. Яагаад гэвэл, мэдээллийг туйлын тодорхой байдлаар шалгах боломжгүй боловч тухайн мэдээлэл нь эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийг үнэн зөв илэрхийлж болох юм. Түүнчлэн, шалгах боломжтой байдал нь НЗСТ-д толилуулсан мэдээллийн ач холбогдолтой байдалд хувь нэмрээ оруулахын тулд үнэн зөв илэрхийлэл болон бусад чанарын шинжүүдтэй янз бүрийн арга замаар харилцан үйлчилж болох юм. Тухайлбал; мэдээллийн агуулж болох зүйлийн шалгах боломжтой байдлын зэрэг хэмжээ ба түүнийг цаг хугацаанд нь толилуулсан бөгөөд хамааралтай гэдгийг магадлан баталгаажуулах бусад чанарын шинжүүдийн хоорондох зохих тэнцвэрийг хангах шаардлагатай байж болно.

ДҮ3.25. Онолын үзэл баримтлалд заасан чанарын шинжүүдийг боловсруулах үедээ УСНББОУСЗ нь НЗСТ-д толилуулах боловч санхүүгийн тайланд тусгахгүй мэдээллийн хувьд мөрдөх тусдаа шинж байдлаар “дэмжигдэх боломжтой байдал”-ыг тодорхойлох хэрэгтэй эсэхийг харгалзан үзсэн. Үндсэндээ ижил шинж чанар бүхий шалгах боломжтой байдал ба дэмжигдэх боломжтой байдал гэсэн хэллэгийн аль алиныг тусдаа чанарын шинж байдлаар тодорхойлох нь НЗСТ-гийн бэлтгэгчид, хэрэглэгчид болон бусад хүмүүсийг

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

будлихад хүргэж болно гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Харин НЗСТ-д тусгасан тайлбар мэдээлэл, хэтийн санхүүгийн ба санхүүгийн бус мэдээлэл нь өөрийн илэрхийлэн харуулахыг зорьж буй эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийг үнэн зөв илэрхийлсэн гэдгийг хэрэглэгчдэд батлан харуулахад тусалдаг мэдээллийн шинж чанарыг илэрхийлэхийн тулд дэмжигдэх боломжит байдал хэллэгийг зарим үед ашигладаг болохыг Онолын үзэл баримтлалд дурдсан.

ДҮЗ.26. Саналын Төсөлд хариулт ирүүлсэн зарим хүмүүс нь санхүүгийн тайланд хамаарахгүй боловч НЗСТ-д толилуулж болох өргөн хүрээтэй асуудалд, ялангуяа тухайн тайлант үеийн турш дахь үйлчилгээ үзүүлэх зорилтын хэрэгжилтийн тухай тайлбар мэдээлэл, түүнчлэн хэтийн санхүүгийн болон санхүүгийн бус тоон шинжтэй мэдээлэлд шалгах боломжтой байдлыг мөрдөх талаар санаа зовж буйгаа илэрхийлсэн. УСНББОУСЗ-ийн үзэл бодлоор бол Онолын үзэл баримтлал нь эдгээр асуудлуудын хувьд шалгах боломжтой байдлыг мөрдөх талаархи зохих заавар удирдамжаар хангах юм. Тухайлбал; шалгах боломжтой байдал нь туйлын зүйл биш бөгөөд бүх тоон төлөөлөл болон тайлбаруудын үнэн зөв эсэхийг ирээдүйн тайлант үе хүртэл шалгах боломжгүй байж болох юм гэж тайлбарладаг. Тайлбар, түүнчлэн хэтийн санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийн эмхлэн бүрдүүлэлтэнд хэрэглэсэн уг суурь таамаглалууд ба арга зүйн тодруулга нь үнэн зөв илэрхийлэлд хүрэх гол цөм гэдгийг Онолын үзэл баримтлалд бас дурдсан.

**Чанарын шинжүүдийн ангилал ба тэдгээрийг хэрэглэх эрэмбэ дараалал**

ДҮЗ.27. Саналын Төсөлд хариулт ирүүлсэн зарим хүмүүс нь дараах зүйлсийг Онолын үзэл баримтлалд тодорхойлох хэрэгтэй гэсэн байр суурийг илэрхийлсэн. Үүнд:

- Хамааралтай байх ба үнэн зөв илэрхийллийг чанарын үндсэн шинж гэж тодорхойлж, тэдгээрийг хэрэглэх эрэмбэ дарааллыг тайлбарлах;
- Зэрэгцүүлэгдэх боломжтой байх, шалгах боломжтой байх, цаг хугацаандаа байх, ойлгомжтой байх шинжүүдийг чанарын нэмэгдүүлэх шинжүүд гэж тодорхойлох;
- Засгийн газрын олон улсын байгууллагууд.

Энэ нь чанарын шинжүүдийг хэрэглэх эрэмбэ дарааллын талаархи ач холбогдолтой заавар удирдамжаар хангах бөгөөд Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан арга хандлагыг тусгана гэж тэдгээр хүмүүс онцлон тэмдэглэсэн.

ДҮЗ.28. Чанарын шинжүүдийг боловсруулахдаа УСНББОУСЗ нь зарим шинжүүдийг үндсэн, нөгөө заримыг нэмэгдүүлэх гэж тодорхойлох хэрэгтэй эсэхийг харгалзан үзсэн. УСНББОУСЗ нь чанарын шинжүүдийг мөрдөх эрэмбэ дарааллыг тогтоож, тайлбарлах хэрэгтэй эсэхийг бас авч үзсэн.



## УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

УСНББОУСЗ нь тухайлбал, дараах шалтгааны улмаас ийм хандлагыг мөрдөх хэрэггүй гэсэн байр суурьтай байсан. Үүнд:

- Чанарын шинжүүдийн хувьд үндсэн ба нэмэгдүүлэх гэсэн ийм ялгаатай байдал үүсгэх санаа зорилгогүй байсан боловч “үндсэн” гэж тодорхойлсон зүйлс нь “нэмэгдүүлэх” гэж тодорхойлсон зүйлсээс илүү чухал ач холбогдолтой гэж ойлгогдож болох юм. Иймээс зарим чанарын шинжүүдийг “үндсэн”, нөгөө заримыг “нэмэгдүүлэх” гэж тодорхойлох зориудын бус үр дагавартай байж болно;
- Бүх чанарын шинжүүд нь чухал бөгөөд мэдээллийн ач холбогдолтой байдалд хувь нэмрээ оруулахын тулд хамтран үүрэг гүйцэтгэдэг. Янз бүрийн нөхцөл байдалд тухайн чанарын шинжийн үзүүлэх харьцангуй ач холбогдол нь мэргэжлийн шүүн тунгаалтын асуудал байдаг. Иймээс НЗСТ-д тусган оруулахаар ямар мэдээллийг авч үзэж буй эсэх болон тухайн байгууллагын нөхцөл байдал ба орчноос үл хамааран зарим чанарын шинжүүдийг ямагт үндсэн, нөгөө заримыг зөвхөн нэмэгдүүлэх буюу дэмжих үүрэгтэй гэж тодорхойлох, эсвэл тэдгээрийг хэрэглэх эрэмбэ дарааллыг тусгайлан заах нь тохиромжгүй юм. Түүнчлэн, ойлгомжгүй мэдээллийг, эсвэл тухайн үйл явдлаас хойш хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд хэрэглэгчдэд ач холбогдолгүй болохуйц тийм удаан хугацааны дараа ханган бүрдүүлсэн мэдээллийг хамааралтай мэдээлэл гэж үзэх, ингэснээр эдгээр шинж нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг хангахад үндсэн чухал гэж үзэх эсэх нь эргэлзээтэй юм;
- Улсын секторын байгууллагуудын НЗСТ нь хэд хэдэн тайлант үеүдийн санхүүгийн үр дүн ба үйлчилгээ үзүүлэх зорилтуудын хэрэгжилтийн талаархи түүхэн болон хэтийн мэдээллийг агуулсан байж болно. Энэ нь үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны хандлага болон түүнд зориулсан нөөцийн үнэлгээнд зайлшгүй шаардлагатай орц өгөгдлөөр хангадаг, түүнчлэн ийм хандлагын мэдээний хувьд зэрэгцүүлэгдэх сууриар тайлагнах нь тухайн мэдээллийн үнэн зөв илэрхийлэлтэй адил чухал ач холбогдолтой байж болох бөгөөд үнэн зөв илэрхийллээс салган зааглаж болохгүй юм.

### **Нийтлэг зорилготой санхүүгийн тайланд тусгасан мэдээллийн хязгаарлалтууд**

#### *Материаллаг байдал*

ДҮЗ.29. Саналын Төслийг гаргах үед УСНББОУС 1-ийн Хавсралт А-д материаллаг байдлыг Онолын үзэл баримтлалд заасантай ижил шинж чанартайгаар тодорхойлдог байсан боловч зөвхөн мэдээллийн хамааралтай байдлыг тогтооход харгалзан үзэх хүчин зүйл байдлаар материаллаг байдлыг тодорхойлдог байсан. Саналын Төсөлд хариулт ирүүлсэн зарим хүмүүс нь материаллаг байдлыг хамааралтай байдлын шинж төлөв гэж тодорхойлж болно гэж тэмдэглэж байсан.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

- ДҮ3.30. Материаллаг байдлыг НЗСТ-д тусгасан мэдээллийн хязгаарлалт бус, харин байгууллагын хамааралтай байдлын тусгай төлөв шинж гэж тодорхойлох хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ нь харгалзан үзсэн. Санхүүгийн тайлан бэлтгэгч нь тухайлбал, тодорхой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдөх хэрэгтэй эсэх, эсвэл мэдээллийн зүйлийг тухайн байгууллагын санхүүгийн тайланд тусад нь тодруулвал зохих эсэхийг тодорхойлохдоо Онолын үзэл баримтлалд тайлбарласанчлан, түүнчлэн УСНББОУС-ын шаардлагын дагуу материаллаг байдлыг харгалзан үзнэ.
- ДҮ3.31. Гэвч материаллаг байдал нь зөвхөн тухайн байгууллагын хамааралтай байдлын тусгай төлөв шинж гэсэн өөрийн ангиллаар тусган илэрхийлэхээс илүү өргөн хүрээний үүрэгтэй байдаг гэж УСНББОУСЗ үздэг. Тухайлбал; материаллаг байдал нь НЗСТ-д тусгасан мэдээллийн чанарын олон шинжүүдтэй холбоотой бөгөөд тэдгээрт нөлөө үзүүлж чадах юм. Иймээс мэдээллийн зүйлийн орхигдуулалт буюу буруу илэрхийлэлт нь зөвхөн хамааралтай байдал төдийгүй НЗСТ-д толилуулсан санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийн үнэн зөв илэрхийлэл, ойлгомжтой байдал буюу шалгах боломжтой байдалд сөргөөр нөлөөлж чадах эсэхийг тодорхойлохдоо тухайн зүйлийн материаллаг байдлыг харгалзан үзвэл зохино. Тодорхой нягтлан бодох бүртгэлийн бодлого буюу тайлан бэлтгэх суурийн мөрдөлт, эсвэл мэдээллийн зарим зүйлсийн тусдаа тодруулгын мэдээллийн агуулгын үр нөлөө нь материаллаг байх магадлалтай эсэхийг УСНББОУСЗ нь УСНББОУС болон СБПУ-ийг боловсруулахдаа мөн харгалзан үзэх хэрэгтэй гэсэн байр суурьтай байдаг. Иймээс УСНББОУСЗ нь НЗСТ-д тусгах мэдээллийн өргөн хүрээтэй хязгаарлалт байдлаар материаллаг байдлыг илүү сайн тусган илэрхийлнэ гэж үздэг.
- ДҮ3.32. Улсын секторын байгууллагуудын хувьд УСНББОУС-аас гадна санхүүгийн тайлагналын шаардлагуудыг тогтоож болох хууль тогтоомж, зохицуулалт буюу бусад бүрэн эрхийг Онолын үзэл баримтлалд тусгах хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн. НЗСТ-д тусгасан мэдээлэлд хууль тогтоомж буюу бусад бүрэн эрхийн үзүүлж болох үр нөлөө нь улсын секторын (болон хувийн хэвшлийн) олон байгууллагын үйл ажиллагаа явуулдаг орчны нэг шинж боловч санхүүгийн тайлагналын ойлголт ухагдахуун биш гэж УСНББОУСЗ үзсэн. Иймээс УСНББОУСЗ нь үүнийг Онолын үзэл баримтлалд дээрх байдлаар тодорхойлоогүй. Тайлан бэлтгэгч нар нь НЗСТ-г бэлтгэхдээ ийм шаардлагуудыг мэдээж харгалзан үзнэ. Ялангуяа, хууль тогтоомж нь Онолын үзэл баримтлалд тодорхойлсон материаллаг байдлын босго шалгуур (буюу өртөг-өгөөжийн хязгаарлалт)-ыг хангахгүй гэж шүүн үнэлсэн байлаа ч гэсэн тухайн тодорхой мэдээллийн зүйлсийг НЗСТ-д тусган тодруулахаар заасан байж болно. Үүнтэй адилаар зарим зүйлс нь материаллаг бөгөөд өртөг-өгөөжийн хязгаарлалтыг хангадаг байлаа ч гэсэн тухайлбал, үндэсний аюулгүй байдлын асуудалтай холбоотойн улмаас түүнийг тодруулахыг хууль тогтоомжоор хориглож болох юм.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

*Өртөг-өгөөж*

ДҮЗ.33. Байгууллагууд нь УСНББОУС-ын тодорхой шаардлагуудын хувьд өртөг-өгөөжийн талаархи өөрийн үнэлгээндээ үндэслэн УСНББОУС-аас гажих шийдвэр гаргаж болохгүй гэдгийг уг санал болгож буй Онолын үзэл баримтлалын текстэнд тусгайлан заагаагүй байна гэдгийг Саналын Төсөлд хариулт ирүүлсэн зарим хүмүүс илэрхийлсэн. Харин УСНББОУСЗ нь ингэж тусгайлан заах шаардлагагүй гэж үзсэн. Яагаад гэвэл, Онолын үзэл баримтлалын 1.2-р параграфт дурдсанчлан, НЗСТ дахь хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, толилуулгатай холбоотой бүрэн эрхэт шаардлагуудыг УСНББОУС-уудад тусгайлан заадаг. Хэрэглэгчдэд ач холбогдолтой мэдээллээр хангахын тулд НЗСТ-г бэлтгэдэг бөгөөд шаардлагуудыг даган мөрдсөнөөр хэрэглэгчдэд өгөх өгөөж нь түүний өртөг зардлыг зөвтгөн батална гэж УСНББОУСЗ-өөс үнэлсэн зөвхөн тийм тохиолдолд тухайн шаардлагыг УСНББОУС-д оруулан тодорхойлдог. Гэвч тайлан бэлтгэгч нар нь тухайлбал, УСНББОУС-аар шаардсанаас бусад, мэдээллийн тодруулгыг НЗСТ-д тусган оруулах эсэхийг тодорхойлохдоо өртөг, өгөөжийг харгалзан үзэж болох юм.

ДҮЗ.34. Улсын секторын янз бүрийн байгууллагуудын хувьд өртөг-өгөөжийн тэнцвэр өөр өөр байж болохыг уг санал болгож буй Онолын үзэл баримтлалд хүлээн зөвшөөрөөгүй гэдгийг Саналын Төсөлд хариулт ирүүлсэн зарим хүмүүс бас илэрхийлсэн. Үүнийг хүлээн зөвшөөрөх нь тайлагналын янз бүрийн асуудлуудыг авч үзэх үедээ хэрэглэх ач холбогдолтой зарчмаар хангаж болох юм гэж тэдгээр хүмүүс үзэж байсан. УСНББОУСЗ нь эдгээр асуудлуудыг авч хэлэлцсэн бөгөөд өөр өөр тайлагналтай холбоотой асуудлууд, үүн дотроо тухайн тодорхой шаардлагуудын өртөг, өгөөж нь янз бүрийн байгууллагуудын хувьд өөр өөр байж болох эсэхийг Онолын үзэл баримтлалаар зохицуулахгүй гэж шийдвэрлэсэн.

ДҮЗ.35. УСНББОУС болон СБПУ-ийг боловсруулахдаа, УСНББОУСЗ нь улсын секторын байгууллагуудын НЗСТ-д мэдээллийг тусган оруулсны магадлалт өртөг зардал ба өгөөжийн талаархи орц өгөгдлийг судалж, харгалзан үздэг. Гэвч зарим тохиолдолд УСНББОУСЗ нь тухайлбал, тухайн тодорхой тодруулгыг, үүн дотроо нийтийн ашиг сонирхол буюу УСНББОУС-ын бусад шаардлагын улмаас зайлшгүй шаардлагатай тодруулгыг тусган оруулснаар бий болох магадлалтай бүх өгөөжийг тогтоох ба/буюу тоогоор илэрхийлэх боломжгүй байж болно. Мөн зарим тохиолдолд УСНББОУСЗ нь улсын секторын зарим байгууллагуудын НЗСТ-гийн хэрэглэгчдийн хувьд тухайн шаардлагаас хүртэх өгөөж маш бага гэж үзэж болох юм. Ийм тохиолдолд тухайн тодорхой шаардлагуудыг УСНББОУС-д тусган оруулах хэрэгтэй эсэхийг тодорхойлохын тулд өртөг-өгөөжийн сорилыг хэрэглэх тохиолдолд УСНББОУСЗ-ийн хэлэлцүүлэг нь улсын секторын байгууллагуудад ийм шаардлага тавьснаар түүнийг даган мөрдөхийн тулд улсын секторын байгууллагуудаас хэт их зардал, хүчин чармайлт гаргах магадлалтай эсэхийг мөн харгалзан үзэж болох юм.

## БҮЛЭГ 4: ТАЙЛАГНАГЧ БАЙГУУЛЛАГА

### АГУУЛГА

---

Танилцуулга	Параграф
Тайлагнагч байгууллагын гол шинж чанар	4.1-4.2
Дүгнэлтийн үндэслэл	4.3-4.11

---

## Танилцуулга

- 4.1 Улсын секторын тайлагнагч байгууллага нь НЗСТ бэлтгэдэг засгийн газар болон улсын секторын бусад байгууллага, хөтөлбөр буюу үйл ажиллагааны тодорхойлж болох талбар (цаашид байгууллага буюу улсын секторын байгууллага гэж нэрлэнэ) юм.
- 4.2 Улсын секторын тайлагнагч байгууллага нь НЗСТ-г нэг байгууллага мэтээр толилуулдаг хоёр буюу хэд хэдэн тусдаа байгууллагуудаас бүрдэж болох юм. Ийм тайлагнагч байгууллагыг тайлагнагч групп байгууллага гэж нэрлэдэг.

## Тайлагнагч байгууллагын гол шинж чанар

- 4.3 Улсын секторын тайлагнагч байгууллагын гол шинж чанар нь дараах байдалтай байна. Үүнд:
- Энэ нь иргэд сонгогчдоос буюу тэдний өмнөөс нөөцийг босгон бий болгож, тэдгээр иргэд сонгогчдын ач тусын төлөө эсвэл тэдний өмнөөс үйл ажиллагаа явуулахын тулд уг нөөцийг ашиглан зарцуулдаг байгууллага юм;
  - Хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилго бүхий мэдээллийн хувьд тухайн байгууллагын НЗСТ-гаас хамааралтай, үйлчилгээ хүлээн авагчид буюу нөөцөөр хангагчид байдаг.
- 4.4 Засгийн газар нь яамд буюу газар хэлтэс гэх мэт захиргааны нэгжүүдийг байгуулах буюу тэдгээрээр дамжуулан үйл ажиллагаагаа явуулж болно. Энэ нь иргэд сонгогчдод үйлчилгээ үзүүлэх болон бусад байдлаар дэмжлэг үзүүлэх тусдаа хуулийн статус буюу үйл ажиллагааны бүрэн эрх бүхий итгэмжлэгдсэн этгээд, хууль ёсны эрх бүхий байгууллага, засгийн газрын корпораци ба бусад байгууллагаар дамжуулан үйл ажиллагаагаа бас явуулж болно. Улсын секторын бусад байгууллагууд, үүн дотроо улсын секторын олон улсын байгууллагууд ба нутгийн засаг захиргааны байгууллагууд нь тусдаа хуулийн статус буюу үйл ажиллагааны бүрэн эрх бүхий байгууллагуудаар дамжуулан зарим үйл ажиллагааг мөн эрхлэн явуулж, тэдгээрийн үйл ажиллагааны үр дүнд үр өгөөж хүртэх ба санхүүгийн дарамт буюу алдагдал хүлээж болох юм.
- 4.5 Хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд хэрэглэгчдэд ач холбогдолтой мэдээллийг тайлагнахын тулд НЗСТ-г бэлтгэдэг. Үйлчилгээ хүлээн авагчид ба нөөцөөр хангагчид нь НЗСТ-гийн үндсэн хэрэглэгчид юм. Иймээс тайлагнагч байгууллагын, үүн дотроо тайлагнагч групп байгууллагын гол шинж чанар бол хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгод шаардлагатай мэдээллийн хувьд тухайн байгууллага буюу групп байгууллагын НЗСТ-гаас хамааралтай, үйлчилгээ хүлээн авагчид эсвэл нөөцөөр хангагчид оршин байх явдал юм.
- 4.6 НЗСТ нь санхүүгийн тайлан, түүнчлэн санхүүгийн тайланг бэхжүүлэн сайжруулах, нэмж гүйцээх, дэлгэрүүлэн баяжуулах мэдээллээс бүрддэг.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайлан нь тайлангийн өдрөөрх тухайн тайлагнагч байгууллага буюу тайлагнагч групп байгууллагын нөөц, уг тайлант үеийн туршид тэдгээр нөөц болон нөөцийн нэхэмжлэлд гарсан өөрчлөлтийн талаархи мэдээллийг толилуулдаг. Иймээс санхүүгийн тайланг бэлтгэх боломжтой болгохын тулд тайлагнагч байгууллага нь иргэд сонгогчдын ашиг тусын төлөө буюу тэдний нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулахын тулд нөөцийг бүрдүүлэх ба/буюу өмнө бүрдүүлсэн нөөцийг ашиглан зарцуулдаг.

- 4.7 Улсын секторын байгууллага буюу групп байгууллагуудын НЗСТ-гийн хэрэглэгчид оршин буйг илэрхийлэх хүчин зүйлсэд дараах зүйлс хамаарна: байгууллага нь нөөцийг бүрдүүлэх буюу түүнийг ашиглан зарцуулах, төрийн өмчийг олж эзэмших буюу захиран зарцуулах, өр төлбөрийг хариуцах, үйлчилгээ үзүүлэх зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрхлэн явуулах үүрэг хариуцлагатай буюу чадвар боломжтой байх явдал юм. Улсын секторын байгууллагын бүрдүүлэх, удирдан зохицуулах нөөц, түүнчлэн түүнийг ашиглан зарцуулах чадвар боломж их байх, байгууллагын хариуцах өр төлбөр их байх, байгууллагын үйл ажиллагааны эдийн засгийн болон нийгмийн үр нөлөө их байх тусам хариуцлагын ба шийдвэр гаргалтын зорилгоор эдгээрийн талаархи мэдээллийн хувьд НЗСТ-гаас хамааралтай тийм үйлчилгээ хүлээн авагчид ба нөөцөөр хангагчид оршин байх илүү их магадлалтай юм. Эдгээр хүчин зүйлс байхгүй буюу ач холбогдолгүй тохиолдолд эдгээр байгууллагын НЗСТ-гийн хэрэглэгчид нь оршин байх магадлал багатай юм.
- 4.8 НЗСТ бэлтгэлт нь өртөг зардалгүй үйл явц биш юм. Иймээс санхүүгийн тайлагналын шаардлагууд нь үр ашигтай ба үр дүнтэй байхын тулд ийм хэрэглэгчид оршин буй зөвхөн тэдгээр улсын секторын байгууллагуудаас НЗСТ бэлтгэхийг шаардах нь чухал ач холбогдолтой байдаг.
- 4.9 Хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилго бүхий мэдээллийн хувьд улсын секторын байгууллагын НЗСТ-гаас хамааралтай, үйлчилгээ хүлээн авагчид буюу нөөцөөр хангагчид оршин буй эсэх нь ихэнх тохиолдолд тодорхой ойлгомжтой байдаг. Жишээлбэл; үндэсний, мужийн, орон нутгийн түвшний засгийн газрын болон улсын секторын олон улсын байгууллагын НЗСТ-гийн хувьд ийм хэрэглэгчид оршин байх магадлалтай юм. Яагаад гэвэл, эдгээр засгийн газрууд болон байгууллагууд нь өөрсдийн иргэд сонгогчдоос мэдэгдэхүйц хэмжээний нөөцийг босгон бүрдүүлэх ба/буюу тэдний өмнөөс мэдэгдэхүйц хэмжээний нөөцийг ашиглан зарцуулах, өр төлбөр үүсгэх, үйлчилгээний нийлүүлэлтээс хамааралтай байх ард иргэдийн эдийн засгийн болон нийгмийн аж байдалд ерөнхийдөө нөлөөлөх чадвар боломжтой байдаг.
- 4.10 Гэвч НЗСТ-гаас хамааралтай, үйлчилгээ хүлээн авагчид буюу нөөцөөр хангагчид оршин буй эсэх нь ямагт тодорхой ойлгомжтой биш байж болох юм. Жишээлбэл; хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилго бүхий мэдээллийн хувьд засгийн газрын бие даасан газар хэлтэс ба агентлаг, тухайн тодорхой хөтөлбөр буюу үйл ажиллагааны тодорхойлж болох талбар байх эсэх нь тодорхойгүй байж болно. Эдгээр байгууллага, хөтөлбөр, үйл ажиллагааг тайлагнагч байгууллага гэж тодорхойлох,

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

ингэснээр НЗСТ бэлтгэхийг тэднээс шаардах эсэх нь мэргэжлийн шүүн тунгаалтыг шаарддаг.

- 4.11 Засгийн газар болон улсын секторын бусад зарим байгууллага нь хуульд заасан тусдаа статус буюу төлөв байдал (хууль ёсны статус)-тай байдаг. Гэвч тусдаа хуулийн статусгүй улсын секторын байгууллага, хөтөлбөр, үйл ажиллагаа нь үйлчилгээ үзүүлэх зорилтонд хүрэх буюу засгийн газрын бодлогыг өөр бусад байдлаар хэрэгжүүлэхийн тулд мөн нөөцийг үүсгэн бүрдүүлж, ашиглан зарцуулж, төрийн өмчийг олж эзэмших буюу удирдан зохицуулж, өр төлбөр үүсгэж, үйл ажиллагааг эрхлэн явуулж болох юм. Үйлчилгээ хүлээн авагчид ба нөөцөөр хангагчид нь хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилго бүхий мэдээллийн хувьд эдгээр байгууллага, хөтөлбөр, үйл ажиллагааны НЗСТ-гаас хамааралтай байж болно. Иймээс улсын секторын тайлагнагч байгууллага нь тусдаа хуулийн статустай, эсвэл тусдаа хуулийн статусгүй тухайлбал, байгууллага, захиргааны зохион байгуулалт эсвэл хөтөлбөр байж болох юм.

## **Дүгнэлтийн үндэслэл**

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь Онолын Үзэл Баримтлалыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### **Тайлагнагч байгууллагын гол шинж чанар**

ДҮ4.1. Тайлагнагч байгууллагын ойлголт ухагдахуун нь улсын секторын байгууллагуудын санхүүгийн тайлагналын зорилтоос урган гардаг. Улсын секторын байгууллагуудын санхүүгийн тайлагналын зорилт нь хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгоор НЗСТ-гийн хэрэглэгчдэд ач холбогдолтой тухайн байгууллагын талаархи мэдээллээр хангах явдал юм.

ДҮ4.2. Тайлагнагч байгууллагууд нь НЗСТ-г бэлтгэдэг. НЗСТ нь байгууллагын санхүүгийн байдал, үр дүн, мөнгөн гүйлгээ гэх мэт асуудлуудын талаархи мэдээллийг толилуулдаг санхүүгийн тайлан, түүнчлэн санхүүгийн тайланг бэхжүүлэн сайжруулах, нэмж гүйцээх, дэлгэрүүлэн баяжуулах санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг агуулсан байдаг. Иймээс улсын секторын тайлагнагч байгууллагын гол шинж чанар нь хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилго бүхий мэдээллийн хувьд засгийн газрын буюу улсын секторын бусад байгууллагын НЗСТ-гаас хамааралтай, үйлчилгээ хүлээн авагчид ба нөөцөөр хангагчид оршин байх явдал юм.

### **Хууль тогтоомж, зохицуулалт буюу бусад бүрэн эрх**

ДҮ4.3. Улсын секторын ямар байгууллагыг тайлагнагч байгууллага буюу тайлагнагч групп байгууллага гэж тодорхойлох, ингэснээр НЗСТ бэлтгэхийг тэднээс шаардах хэрэгтэй эсэхийг Саналын Төсөлд тусгайлан заагаагүй. НЗСТ-г бэлтгэвэл зохих улсын секторын байгууллага ба хөтөлбөрийг хууль тогтоомж, зохицуулалт болон бусад бүрэн эрхэд тусгайлан заах буюу улс орон бүрийн холбогдох эрх бүхий байгууллагаас тодорхойлно гэдгийг тэмдэглэсэн.

ДҮ4.4. НЗСТ-г ямар байгууллага бэлтгэхийг практикт хууль тогтоомж буюу бусад бүрэн эрхэд тусгайлан зааж болох боловч Онолын үзэл баримтлал нь тайлагнагч байгууллага гэсэн ойлголт ухагдахуунд голлон төвлөрч, уг ойлголт ухагдахууны гол онцлог шинжийг тодорхойлох ба тайлагнагч байгууллага оршин буй эсэхийг тодорхойлохдоо харгалзан үзвэл зохих зарчмууд болон хүчин зүйлсийн талаархи заавар удирдамж хангах хэрэгтэй гэсэн байр суурийг хариулт өгсөн зарим хүмүүс илэрхийлсэн. УСНББОУСЗ нь эдгээр шалтгаан үндэслэлийг харгалзан үзээд өөрийн хэлэлцүүлгийг уг тайлагнагч байгууллага гэсэн ойлголт ухагдахууныг тайлбарлахад чиглүүлсэн.

### **Тайлбар ба мөрдөлт**

ДҮ4.5. Аль нэг байгууллагын тодорхой үйл ажиллагаа буюу сегментийг тусдаа тайлагнагч байгууллага гэж тодорхойлохын тулд Саналын Төсөлд дурдсан,



## УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

тайлагнагч байгууллагын шинж чанаруудыг ашиглаж болох юм гэдэгт санаа зовж буйгаа хариулт өгсөн зарим хүмүүс илэрхийлсэн. Ингэснээр бүх УСНББОУС-уудад нийцсэн НЗСТ бэлтгэхийг тэдгээр сегмент буюу үйл ажиллагаанаас шаардахад хүрнэ. Санал Төсөлд дурдсан, заавар удирдамжийг засгийн газраас бусад улсын секторын байгууллагуудад, тухайлбал, улсын секторын олон улсын байгууллагуудад хэрхэн мөрдөх нь ойлгомжгүй байна гэдгийг хариулт өгсөн өөр зарим хүмүүс бас тэмдэглэсэн.

ДҮ4.6. УСНББОУСЗ нь эдгээр асуудалд хариулт өгсөн. НЗСТ бэлтгэлт нь өртөг зардалгүй үйл явц биш гэдгийг Үзэл баримтлалд тайлбарласан. Мөн Үзэл баримтлал нь:

- Хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилго бүхий мэдээллийн хувьд засгийн газрын буюу улсын секторын бусад байгууллагын НЗСТ-гаас хамааралтай, үйлчилгээ хүлээн авагчид ба нөөцөөр хангагчид оршин буйг илтгэх магадлалтай хүчин зүйлсийн талаархи нэмэлт заавар удирдамжийг агуулсан байдаг;
- Улсын секторын янз бүрийн байгууллага, хөтөлбөр, үйл ажиллагаа, үүн дотроо засгийн газрын хэлтэс газар, агентлаг, улсын секторын олон улсын байгууллагыг тайлагнагч байгууллага гэж тодорхойлоход эдгээр хүчин зүйлсийн үзүүлэх боломжит үр нөлөөг тусган тэмдэглэсэн.

ДҮ4.7. Зарим тохиолдолд, улсын секторын тухайн тодорхой байгууллагыг тайлагнагч байгууллага гэж тодорхойлох эсэхийг тогтооходоо мэргэжлийн шүүн тунгаалт хийх шаардлагатай байж болно гэдгийг Онолын үзэл баримтлалд тэмдэглэсэн. Засгийн газрын буюу улсын секторын бусад тайлагнагч байгууллагын хэрэгжүүлсэн тодорхой хөтөлбөр ба үйл ажиллагааны талаархи хэрэглэгчдийн мэдээллийг хэрэгцээг УСНББОУС-ууд нь тэрхүү засгийн газрын болон улсын секторын бусад тайлагнагч байгууллагын НЗСТ-д тусдаа тодруулга оруулах замаар зарим тохиолдолд хангадаг гэдгийг шүүн тунгаалт хийх үедээ анхаарах хэрэгтэй.<sup>5</sup> Хууль тогтоолтын болон зохицуулалтын хүчин төгөлдөр үйлчлэлийн хүрээ, нөөцийн бүрдүүлэлт ба үйлчилгээний нийлүүлэлтийн бүтэц зохион байгуулалтын болон захиргааны арга хэмжээ гэх мэт хууль эрх зүйн хүчин зүйлс нь тухайн улсын секторын байгууллагуудын НЗСТ-гаас хамааралтай, үйлчилгээ хүлээн авагчид ба нөөцөөр хангагчид оршин буй эсэх талаархи санал хэлэлцүүлгийг мөн илэрхийлэх магадлалтай байдаг.

---

<sup>5</sup> Жишээлбэл, УСНББОУС 18, *Сегментийн Тайлагнал*, УСНББОУС 22, *Засгийн Газрын Үндсэн Секторын Талаархи Санхүүгийн Мэдээллийн Тодруулга* гэх мэт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ууд нь байгууллагын тодорхой сегмент буюу секторыг тусдаа тайлагнагч байгууллага гэж тодорхойлохгүйгээр тэдгээрийн талаархи хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээг хангах механизмыг тусгасан байдаг.

### Тайлагнагч групп байгууллага

ДҮ4.8. Байгууллага буюу үйл ажиллагааг улсын секторын тайлагнагч групп байгууллагын бүрэлдэхүүнд тусган оруулахыг зөвтгөн батлах нөхцлүүдийг Саналын Төсөлд дурдсан. Энд дараах байдлаар тайлбарласан:

- Засгийн газар буюу улсын секторын бусад байгууллага нь (а) нэг буюу хэд хэдэн өөр бусад байгууллагуудын үйл ажиллагаанаас өгөөж хүртэхийн тулд тэдгээрийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх бүрэн эрхтэй ба чадвар боломжтой байж болох юм, (б) тэдгээр байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд үүсэх санхүүгийн дарамт буюу алдагдлыг хүлээж болох юм;
- Засгийн газрын болон улсын секторын бусад байгууллагын хувьд бэлтгэсэн, тайлагнагч групп байгууллагын НЗСТ нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг хангахын тулд тухайн засгийн газрыг (буюу улсын секторын бусад байгууллагыг), түүнчлэн үйл ажиллагааг нь удирдан чиглүүлэх бүрэн эрх ба чадвар боломж бүхий байгууллагуудыг дараах тохиолдолд тусган агуулсан байвал зохино. Үүнд: ингэж удирдан чиглүүлсний үр дүнд (а) уг засгийн газарт (буюу улсын секторын бусад байгууллагад) санхүүгийн болон бусад өгөөж бий болгох, эсвэл (б) түүнд санхүүгийн дарамт буюу алдагдал хүлээлгэдэг байх.

ДҮ4.9. Улсын секторын тайлагнагч групп байгууллагад тусган оруулахын тулд хангавал зохих шалгуурын талаархи УСНББОУСЗ-ийн байр суурьтай санал нийлж буйгаа Саналын Төсөлд хариулт ирүүлсэн олон хүмүүс илэрхийлэн тэмдэглэсэн. Гэвч хариулт ирүүлсэн өөр бусад хүмүүс нь тодорхой нөхцөл байдалд уг шалгуурын боломжит тайлбар ба хэрэглээний талаар санаа зовж буйгаа илэрхийлсэн. Мөн зарим тохиолдолд Онолын үзэл баримтлал нь УСНББОУС-д авч үзээгүй нөхцөл байдлыг илүү үр дүнтэйгээр зохицуулахаар байвал мөрдөх нэмэлт заавар удирдамжаар хангах шаардлагатай гэдгийг тэдгээр хүмүүс тэмдэглэсэн. Тайлагнагч групп байгууллагад тусган оруулахын тулд хангавал зохих шалгуур болон тэдгээрийн үр дагаврыг янз бүрийн нөхцөл байдалд туршин сорьж, олон улс оронд оршин байх магадлалтай нөхцөл байдлын тусгай жишээгээр дэмжин магадалж болох тохиолдолд тэдгээр шалгуурыг стандартын түвшинд илүү тохиромжтой байдлаар авч үзэж, шийдвэрлэнэ гэсэн байр суурийг хариулт өгсөн олон хүмүүс бас илэрхийлж байсан.

ДҮ4.10. УСНББОУСЗ нь эдгээр санаа зовж буй асуудлуудыг үнэмшилтэй гэж үзсэн. УСНББОУСЗ нь улсын секторын тайлагнагч байгууллагын тодорхойлолтын суурь үндэслэл болох зарчмуудад, өөрөөр хэлбэл, тухайн тайлагнагч байгууллага нь улсын секторын нэг байгууллагаас эсвэл групп байгууллагуудаас бүрддэг эсэхэд голлон чиглэхийн тулд тайлагнагч байгууллага болон тайлагнагч групп байгууллагын талаархи өөрийн хэлэлцүүлгийг дахин зохион байгуулж, тодорхойлсон. Тайлагнагч групп байгууллагад тусган оруулахын тулд хангавал зохих шалгуурыг эдгээр зарчмуудтай нийцсэн байдлаар боловсруулж, стандартын түвшинд бүрэн судлан үзэх юм.

## БҮЛЭГ 5: САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ЭЛЕМЕНТҮҮД

### АГУУЛГА

---

	Параграф
Танилцуулга	5.1-5.5
Энэ бүлгийн зорилго	5.1
Элементүүд ба тэдгээрийн ач холбогдол	5.2-5.4
Тодорхойлсон элементүүд	5.5
Хөрөнгө	5.6-5.13
Тодорхойлолт	5.6
Нөөц	5.7-5.10
Байгууллагын одоо хянаж буй	5.11-5.12
Өнгөрсөн үйл явдал	5.13
Өр төлбөр	5.14-5.26
Тодорхойлолт	5.14
Одоогийн үүрэг	5.15
Байгууллагаас нөөцийг гадагш зарцуулалт	5.16
Өнгөрсөн үйл явдал	5.17
Хуулиар хүлээсэн болон хуулиар хүлээгээгүй заавл биелүүлэх үүрэг	5.18-5.26
Цэвэр санхүүгийн байдал, бусад нөөц ба бусад үүрэг	5.27-5.28
Орлого ба зардал	5.29-5.31
Тодорхойлолт	5.29-5.31
Тайлант үеийн ашиг, алдагдал	5.32
Өмчлөлийн хувь оролцоо ба өмчлөлийн хуваарилалт	5.33-5.37
Тодорхойлолт	5.33-5.37
Дүгнэлтийн үндэслэл	

---

## Танилцуулга

### Энэ бүлгийн зорилго

- 5.1 Энэ бүлэг нь санхүүгийн тайланд ашиглах элементүүдийг тодорхойлох бөгөөд тэдгээр тодорхойлолтын талаархи цаашдын тайлбараар хангана.

### Элементүүд ба тэдгээрийн ач холбогдол

- 5.2 Санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба бусад үйл явдлуудын санхүүгийн үр нөлөөг тэдгээрийн эдийн засгийн нийтлэг шинжийг агуулсан ерөнхий ангиудаар бүлэглэн харуулдаг. Эдгээр ерөнхий ангиудыг санхүүгийн тайлангийн элементүүд гэж томъёолдог. Элементүүд нь санхүүгийн тайланг бүрдүүлэн гаргах бүрэлдэхүүн хэсгүүд юм. Эдгээр бүрэлдэхүүн хэсгүүд нь НЗСТ-д тусган оруулах мэдээллийн хязгаарлалтуудыг харгалзахын зэрэгцээгээр санхүүгийн тайлагналын зорилтуудад хүрч, санхүүгийн тайлагналын чанарын шинжүүдийг биелүүлэх мэдээллээр хэрэглэгчдийг хангах тийм арга замаар эдийн засгийн мэдээ болон үйл ажиллагааг бүртгэх, ангилах, нэгтгэх эхлэлийн цэг болдог.
- 5.3 Энэ бүлэгт тодорхойлсон элементүүд нь ажил гүйлгээ ба үйл явдлын үр дүнд хүлээн зөвшөөрдөг бие даасан зүйлсэд хамаарахгүй. Санхүүгийн тайлангийн ойлгомжтой байдлыг нэмэгдүүлэхийн тулд элемент, түүнчлэн зүйлсийн нэгдлийн хүрээн дэх бие даасан зүйлсийн дэд ангиллыг ашигладаг. Толилуулгын талаар Бүлэг 8, *Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлан дахь Толилуулга*-д авч хэлэлцсэн.
- 5.4 Санхүүгийн тайлан нь байгууллагын санхүүгийн үр дүн ба санхүүгийн байдлын зохих үнэлгээнд ач холбогдолтой мэдээллээр хангадаг эсэхийг магадлахын тулд зарим тохиолдолд энэ Бүлэгт тодорхойлсон элементүүдэд тусгагдаагүй эдийн засгийн юмс үзэгдлийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай байж болох юм. Иймээс санхүүгийн тайлагналын зорилтуудыг илүү сайн хангахад шаардлагатай гэж үзсэн тохиолдолд УСНББОУС нь энэ Бүлэгт тодорхойлсон элементийн тодорхойлолтыг хангахгүй тийм нөөц болон үүрэг (цаашид “бусад нөөц” эсвэл “бусад үүрэг” гэж нэрлэнэ) хүлээн зөвшөөрөхийг шаардах буюу зөвшөөрөхөд энэ Бүлэг дэх элементийн тодорхойлолт саад учруулахгүй.

### Тодорхойлсон элементүүд

- 5.5 Энэ Бүлэгт дараах элементүүдийг тодорхойлсон:

- Хөрөнгө;
- Өр төлбөр;
- Орлого;
- Зардал;
- Өмчлөлийн хувь оролцоо;

- Өмчлөлийн хуваарилалт.

## Хөрөнгө

### Тодорхойлолт

5.6 Хөрөнгө гэдэг нь:

*Өнгөрсөн үйл явдлын үр дүнд байгууллага одоо хяналтандаа оруулсан нөөц юм.*

### Нөөц

5.7 Нөөц гэдэг нь үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөж бий болгох чадвар бүхий зүйл юм. Биет хэлбэр нь нөөцийн зайлшгүй шаардлагатай нөхцөл биш юм. Үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөж бий болгох чадвар нь тухайн нөөцөөс өөрөөс нь, эсвэл уг нөөцийг ашиглах эрхээс шууд үүсэж болно. Зарим нөөц нь янз бүрийн өгөөжийг хүртэх уг байгууллагын эрхийг өөртөө агуулдаг. Үүнд: тухайлбал, дараах эрх хамаарна:

- Үйлчилгээ үзүүлэхийн тулд нөөцийг ашиглах;<sup>6</sup>
- Үйлчилгээ үзүүлэхдээ гаднын этгээдийн нөөцийг ашиглах. Жишээлбэл, санхүүгийн түрээс;
- Нөөцийг данснаас хасах замаар мөнгө болгон хөрвүүлэх;
- Нөөцийн үнэ цэнийн өсөлтөөс өгөөж хүртэх;
- Мөнгөн орлогын гүйлгээг хүлээн авах.

5.8 Үйлчилгээний чадавхи гэдэг нь тухайн байгууллагын зорилтуудыг биелүүлэхэд хувь нэмэр оруулах үйлчилгээг үзүүлэх чадвар юм. Үйлчилгээний чадавхи нь цэвэр мөнгөн орлогын гүйлгээг заавал бий болгохгүйгээр өөрийн зорилтуудад хүрэх боломжийг байгууллагад олгодог.

5.9 Үйлчилгээний чадавхи бүхий улсын секторын хөрөнгөнд засгийн газрын ба улсын секторын бусад байгууллагуудын эзэмшиж байгаа бөгөөд гуравдагч талд үйлчилгээ үзүүлэхийн тулд ашигладаг амралт зугаалгын, соёлын өвийн, батлан хамгаалахын болон бусад хөрөнгүүд хамаарч болох юм. Ийм үйлчилгээ нь хамтын эсвэл бие даасан ашиглалт хэрэглээнд зориулагдсан байж болно. Олон үйлчилгээг зах зээлийн өрсөлдөөнгүй буюу зах зээлийн хязгаарлагдмал өрсөлдөөнтэй талбарт үзүүлж болох юм. Шинж төрлөөр төрөлжүүлсэн үйлчилгээний чадавхи бүхий олон хөрөнгийн адилаар эдгээр хөрөнгийн ашиглалт болон данснаас хасалтыг хязгаарлаж болох юм.

---

<sup>6</sup> Онолын үзэл баримтлал дахь “үйлчилгээ” гэсэн хэллэгт “бараа” хамаардаг.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

5.10 Эдийн засгийн үр өгөөж нь мөнгөн орлогын гүйлгээ эсвэл мөнгөн зарлагын гүйлгээний бууралт юм. Мөнгөн орлогын гүйлгээ (эсвэл мөнгөн зарлагын гүйлгээний бууралт) нь тухайлбал, дараах зүйлсээс үүсэж болно:

- Үйлдвэрлэл ба үйлчилгээний борлуулалтанд хөрөнгийг ашиглалт;
- Хөрөнгийг мөнгө буюу бусад нөөцөөр шууд арилжилт.

**Байгууллагын одоо хянаж буй**

5.11 Байгууллага нь нөөцийг хянадаг байх ёстой. Нөөцийн хяналт нь нөөцийг ашиглах (буюу түүний ашиглалтын хувьд бусад талуудыг удирдан чиглүүлэх), ингэснээр өөрийн үйлчилгээ үзүүлэх болон бусад зорилтуудыг биелүүлэхдээ тухайн нөөцөд агуулагдаж буй үйлчилгээний чадавхийн өгөөж буюу эдийн засгийн үр өгөөжийг гарган ашиглах уг байгууллагын чадварыг бүрдүүлдэг.

5.12 Нөөцийг одоо хянаж буй эсэхээ тогтоохдоо, байгууллага нь хяналтын дараах үзүүлэлтүүд оршин байгаа эсэхийг үнэлнэ:

- Хууль ёсны өмчлөл;
- Нөөцөд хандан нэвтрэлт, эсвэл нөөцөд хандан нэвтрэлтийг хориглох буюу хязгаарлах чадавхи;
- Өөрийн зорилтуудад хүрэхийн тулд нөөцийг ашигладаг эсэхийг ханган магадлах арга хэрэгслүүд;
- Нөөцөөс үүсэх үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөжийг бий болгох чадварын хувьд хууль ёсны эрхтэй байх.

Эдгээр үзүүлэлтүүд нь хяналт оршин буй эсэх тодорхойлох дүгнэлтийн шинжтэй үзүүлэлт биш боловч эдгээр үзүүлэлтийн тодорхойлолт болон шинжилгээ нь ийм шийдвэрийн үндэслэл болно.

**Өнгөрсөн үйл явдал**

5.13 Байгууллагын одоо хянаж буй нөөц нь өнгөрсөн ажил гүйлгээ буюу өнгөрсөн бусад үйл явдлаас үүссэн байхыг хөрөнгийн тодорхойлолтоор шаарддаг. Нөөцийн, иймээс хөрөнгийн хяналтыг байгууллага олж авахад хүргэдэг өнгөрсөн ажил гүйлгээ буюу бусад үйл явдал нь янз бүр байж болно. Байгууллага нь хөрөнгийг арилжааны ажил гүйлгээгээр худалдан авснаар эсвэл тэдгээрийг хөгжүүлэн боловсруулснаар олж авч болно. Хөрөнгө нь арилжааны бус ажил гүйлгээнээс, үүн дотроо бүрэн эрхийн хэрэгжүүлэлтээс бас үүсэж болох юм. Татвар ногдуулах, тусгай зөвшөөрөл олгох, түүнчлэн цахилгаан соронзон орон гэх мэт биет бус нөөцөд агуулагдаж буй үр өгөөжид хандан нэвтрэх, эсвэл хандан нэвтрэлтийг хязгаарлах буюу хориглох бүрэн эрх нь хөрөнгө үүсэхэд хүргэж болох улсын секторын тусгай эрх мэдэл ба бүрэн эрхийн жишээ юм. Нөөц дэх байгууллагын эрхийн хяналт нь хэзээ үүсдэг эсэхийг үнэлэхдээ дараах үйл явдлуудыг харгалзан үзэж болох юм: (а) бүрэн эрхийг ерөнхий чадавхи, (б) эрх зүйн актаар бүрэн эрх тогтоолт, (в) эрх үүсгэх бүрэн эрхийн

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

хэрэгжүүлэлт, (г) гаднын талаас нөөц хүлээн авах эрх үүсгэх үйл явдал. Бүрэн эрхийг хэрэгжүүлсэн ба нөөцийг хүлээн авах эрх оршин байх тохиолдолд хөрөнгө үүсдэг.

## **Өр төлбөр**

### **Тодорхойлолт**

5.14 Өр төлбөр гэдэг нь:

*Өнгөрсөн үйл явдлын үр дүнд нөөцийг гадагш зарцуулах уг байгууллагын одоогийн үүрэг юм.*

### **Одоогийн үүрэг**

5.15 Улсын секторын байгууллагууд нь олон тооны үүрэгтэй байдаг. Одоогийн үүрэг нь хуулиар хүлээсэн заавал биелүүлэх үүрэг (хуулиар хүлээсэн үүрэг) эсвэл хуулиар хүлээгээгүй заавал биелүүлэх үүрэг юм. Хуулиар хүлээгээгүй заавал биелүүлэх үүргийн хувьд байгууллага нь зайлсхийх боломжгүй буюу боломж байлаа гэхэд маш бага байдаг. Заавал биелүүлэх үүрэг, түүнчлэн нөөцийг гадагш зарцуулахаас зайлсхийх боломжгүй буюу боломж байлаа гэхэд маш бага байхаас бусад тохиолдолд үүрэг нь одоогийн үүрэг болохгүй юм.

### **Байгууллагаас нөөцийг гадагш зарцуулалт**

5.16 Өр төлбөр нь түүнийг барагдуулахын тулд байгууллагаас гарах нөөцийн зарцуулалтыг агуулсан байх ёстой. Байгууллагаас нөөцийг гадагш зарцуулахгүйгээр барагдуулж болох үүрэг нь өр төлбөр биш юм.

### **Өнгөрсөн үйл явдал**

5.17 Өр төлбөрийн тодорхойлолтыг хангахын тулд одоогийн үүрэг нь өнгөрсөн ажил гүйлгээ буюу бусад үйл явдлын үр дүнд үүсэх бөгөөд тухайн байгууллагаас нөөцийг гадагш зарцуулахыг шаарддаг байх ёстой. Улсын секторын хөтөлбөр ба үйл ажиллагааны нарийн цогц байдал нь тухайн хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжүүлэлт болон үйл ажиллагаан дахь олон үйл явдлуудаар үүрэг үүсэхэд хүргэж болох юм гэсэн утгыг илэрхийлнэ. Ийм үүрэг ба амлалт, үүн дотроо хуулиар хүчин төгөлдөр хэрэгжихгүй боловч нөөцийг гадагш зарцуулахаас зайлсхийх бодит боломжгүй буюу боломж байлаа гэхэд маш бага байх заавал биелүүлэх үүрэг (хуулиар хүлээгээгүй заавал биелүүлэх үүрэг) нь одоогийн үүрэг бөгөөд өр төлбөрийн тодорхойлолтыг хангах эсэхийг санхүүгийн тайлагналын зорилгоор тодорхойлох шаардлагатай байдаг. Гэрээ гэх мэт хэлцэл нь хуулийн хэлбэртэй бөгөөд заавал биелүүлэх шинжтэй тохиолдолд өнгөрсөн үйл явдлыг тодорхойлоход хялбар байж болно. Өөр бусад тохиолдолд өнгөрсөн үйл явдлыг олж тогтооход илүү төвөгтэй байж болох бөгөөд ингэж тодорхойлохдоо, тухайн байгууллагаас нөөцийг гадагш зарцуулахаас зайлсхийх бодит боломжгүй буюу боломж багатай эсэх

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

үнэлгээг хийдэг. Ийм үнэлгээг хийхдээ байгууллага нь улс орны хүчин зүйлсийг харгалзан үздэг.

**Хуулиар хүлээсэн болон хуулиар хүлээгээгүй заавл биелүүлэх үүрэг**

- 5.18 Заавал биелүүлэх үүрэг нь хуулиар хүлээсэн үүрэг эсвэл хуулиар хүлээгээгүй заавал биелүүлэх үүрэг байж болно. Заавал биелүүлэх үүрэг нь арилжааны болон арилжааны бус ажил гүйлгээний аль алианаас үүсэж болно. Өр төлбөр үүсэхэд хүргэхийн тулд гаднын талын өмнө үүрэг хүлээсэн байх ёстой. Байгууллага нь тодорхой арга замаар ажиллах өөрийн санаа зорилгыг олон нийтэд хүргэн мэдээлсэн байлаа ч гэсэн өөрөө өөрийнхөө өмнө үүрэг хүлээхгүй. Гаднын талыг тодорхойлох нь өр төлбөр үүсэхэд хүргэж буй үүргийн оршин байдлыг илэрхийлэх үзүүлэлт юм. Гэвч одоогийн үүрэг ба өр төлбөрийн оршин байдлын хувьд түүнийг барагдуулах хугацаа болохоос өмнө тухайн гаднын тал хэн болохыг мэдэх нь тийм ч чухал биш юм.
- 5.19 Үүрэг үүсэхэд хүргэдэг олон хэлцэл нь төлбөр барагдуулах хугацааг тусган агуулсан байдаг. Төлбөр барагдуулах хугацааг тусган оруулах нь тухайн үүрэг нөөцийн гадагш зарцуулалтыг агуулах бөгөөд өр төлбөр үүсэхэд хүргэнэ гэсэн үзүүлэлтээр хангаж болох юм. Гэвч төлбөр барагдуулах хугацааг тусган агуулаагүй хэлцэл олон байдаг. Төлбөр барагдуулах хугацаа заагаагүй байх нь уг үүргээр өр төлбөр үүсэхэд саад учруулахгүй юм.

*Хуулиар хүлээсэн үүрэг*

- 5.20 Хуулиар хүлээсэн үүрэг нь хуульд заасны дагуу хүчин төгөлдөр хэрэгждэг. Ийм хууль ёсны хүчин төгөлдөр үүрэг нь янз бүрийн хуулийн илэрхийлэх утгаас үүсэж болох юм. Арилжааны ажил гүйлгээ нь ихэвчлэн гэрээний шинж чанартай байдаг бөгөөд иймээс гэрээний хууль буюу адилтгах эрх болон зохицуулалтаар хууль ёсны хүчин төгөлдөр хэрэгждэг. Засгийн газар болон улсын секторын байгууллагууд нь тухайлбал, өөрийн нэрээр гэрээ байгуулахыг тэдэнд зөвшөөрдөггүй учраас хуулийн үүрэг хүлээдэггүй боловч адилтгах үр нөлөө бүхий хувилбар процесс бүхий тийм улс орнууд байдаг. Ийм адилтгах процессын дагуу заавал биелүүлэх үүргийг Онолын үзэл баримтлалд, хуулиар хүлээсэн үүрэг гэж үзсэн. Зарим төрлийн арилжааны бус ажил гүйлгээний хувьд үүрэг нь хуульд зааснаар хүчин төгөлдөр хэрэгжих эсэхийг тодорхойлохын тулд шүүн тунгаалт хийх шаардлагатай байдаг. Үүрэг нь хуульд заасны дагуу хүчин төгөлдөр хэрэгжинэ гэж тодорхойлсон тохиолдолд тухайн байгууллага нь уг үүргээс зайлсхийх бодит боломжгүй бөгөөд өр төлбөр оршин буй талаар эргэлзээгүй болно.
- 5.21 Арилжааны ажил гүйлгээтэй холбоотой зарим үүрэг нь тухайн тайлангийн өдрөөр гуравдагч тал хууль ёсоор шууд хэрэгжүүлэх боломжгүй байх боловч тэрхүү гуравдагч тал нь барагдуулалтаас өмнө цаашид ямар нэг нөхцлийг ханган биелүүлэхгүй буюу аливаа нэмэлт үйлдэл гүйцэтгэхгүйгээр цаг хугацаа урсан өнгөрөх явцад хууль ёсны хүчин



УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

төгөлдөр болдог. Цаг хугацааны урсан өнгөрөлтөөс хамааран нөхцөлт бусаар хууль ёсны хүчин төгөлдөр болох нэхэмжлэл нь өр төлбөрийн тодорхойлолтын хувьд хүчин төгөлдөр үүрэг юм.

- 5.22 Онцгой бүрэн эрх нь хуулийн зүйл заалтыг тогтоох, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох засгийн газрын туйлын бүрэн эрх юм. Онцгой бүрэн эрх нь энэхүү Үзэл баримтлал дахь өр төлбөрийн тодорхойлолтыг тухайн үүрэг хангахгүй гэж дүгнэх үндэслэл болохгүй. Үүрэг нь цаашид заавал биелүүлэх шинжгүй ба өр төлбөрийн тодорхойлолтыг хангахгүй болсон эсэхийг харгалзан үзэхийн тулд тайлант үеийн эцэс бүрд уг хуулийн төлөв байдлыг үнэлэх хэрэгтэй.

*Хуулиар хүлээгээгүй заавал биелүүлэх үүрэг*

- 5.23 Өр төлбөр нь хуулиар хүлээгээгүй заавал биелүүлэх үүргээс үүсэж болно. Хуулиар хүлээгээгүй заавал биелүүлэх үүрэг нь хуулиар хүлээсэн үүргээс ялгаатай бөгөөд энэ тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг нэхэмжлэгч нь үүргийг барагдуулахын тулд хуулийн (буюу адилтгах) ажиллагаа явуулах боломжгүй байдаг. Өр төлбөр үүсэхэд хүргэдэг, хуулиар хүлээгээгүй заавал биелүүлэх үүрэг нь дараах шинжтэй байдаг:

- Тухайн байгууллага нь өмнөх практикын тогтсон хэв маяг, тогтоосон бодлого буюу тодорхой хариуцлагыг хүлээн зөвшөөрч буйгаа хангалттай тусгайлан заасан одоогийн мэдэгдлийн дагуу нөгөө талдаа өөрийн үүргийг мэдэгдэн илэрхийлдэг;
- Ийм мэдэгдлийн үр дүнд тухайн байгууллага нь өөрийн хариуцлагыг биелүүлнэ гэсэн хүчин төгөлдөр хүлээлтийг тэдгээр бусад талуудад үүсгэдэг;
- Тухайн байгууллага нь эдгээр хариуцлагаас үүсэх үүргийг барагдуулахаас зайлсхийх бодит боломжгүй буюу боломж багатай байдаг.

- 5.24 Улсын секторын хувьд, үүрэг нь хугацааны олон агшинд үүсэж болно. Жишээлбэл; хөтөлбөр буюу үйлчилгээг хэрэгжүүлэх тохиолдолд:

- Сонгуулийн амлалт гэх мэт улс төрийн амлалт гаргах;
- Бодлогыг зарлан мэдэгдэх;
- Төсвийг танилцуулах (ба батлах) (энэ нь хоёр өөр хугацааны агшин байж болно);
- Төсвийг баталж, хүчин төгөлдөр болгох (зарим улс орны хувьд төсвийн хуваарилалтыг хүчин төгөлдөр болгох хүртэл төсөв нь хүчин төгөлдөр болдоггүй);
- Хэрэгжилтийн эхлэлийн үе шат нь өр төлбөрийн тодорхойлолтыг хангах одоогийн үүрэг үүсгэх магадлал багатай байдаг. Харин үзүүлэх үйлчилгээний хувьд зохих шалгуурыг нэхэмжлэгч нь хангах

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

гэх мэт дараагийн үе шатууд нь өр төлбөрийн тодорхойлолтыг хангах үүрэг үүсэхэд хүргэж болох юм.

5.25 Үүргийн дагуу өр төлбөр үүсэхэд хүргэх хугацааны агшин нь тухайн үүргийн шинж төрлөөс хамаардаг. Байгууллага нь нөөцийн гадагш зарцуулалтаас зайлсхийх бодит боломжгүй буюу боломж багатай тийм үүрэг гэж бусад талууд зохих ёсоор дүгнэж болох эсэх шүүн тунгаалтанд нөлөөлөх магадлалтай хүчин зүйлсэд дараах зүйлс хамаарна:

- Үүрэг үүсэхэд хүргэж болох өнгөрсөн үйл явдал буюу үйл явдлуудын шинж төрөл. Жишээлбэл; сонгуулийн амлалт нь түүнийг биелүүлэхээс тухайн байгууллага зайлсхийх боломжгүй буюу боломж багатай гэсэн хүчин төгөлдөр хүлээлтийг гаднын талуудад бараг үүсгэдэггүй учраас сонгуулиар өгсөн амлалт нь одоогийн үүрэг үүсэхэд хүргэх магадлал багатай байдаг. Гэвч гарч тохиолдсон үйл явдал буюу нөхцөл байдалтай холбоотой мэдэгдэл нь засгийн газар түүнээс татгалзах сонголт багатай гэсэн тийм улс төрийн дэмжлэгтэй байж болох юм. Засгийн газар нь төсвийн шаардлагатай заалтыг оруулах амлалт өгсөн ба батлуулах баталгаа гаргасан тохиолдолд ийм мэдэгдэл нь хуулиар хүлээгээгүй заавал биелүүлэх үүрэг үүсэхэд хүргэж болох юм;
- Илт тодорхой болохоос өмнө тухайн үүргийг засварлах буюу өөрчлөх уг байгууллагын чадвар боломж. Жишээлбэл; бодлогын мэдэгдэл нь түүнийг хэрэгжүүлэхээс өмнө засварлан өөрчилж болохгүй, хуулиар хүлээгээгүй заавал биелүүлэх үүргийг ерөнхийдөө үүсгэн бий болгодоггүй. Үүнтэй адилаар, хэрэв үүрэг нь ирээдүйн үйл явдлын гарч тохиолдолтоос болзошгүй хамаардаг бол тэдгээр үйл явдал гарч тохиолдохоос өмнө нөөцийн гадагш зарцуулалтаас зайлсхийх сонголттой байж болно;
- Тодорхой үүргийг барагдуулах санхүүжилтийн бэлэн боломжит байдал ба одоогийн үүргийн үүсэл хооронд харилцан уялдаа холбоо байж болох юм. Жишээлбэл; төсвийн мөрийн зүйлийг баталсан бөгөөд төсвийн хуваарилалт, болзошгүй санхүүжилтийн бэлэн байдал буюу засгийн газрын өөр түвшнээс авах шилжүүлгээр холбогдох санхүүжилтийг баталгаажуулсан тохиолдолд хуулиар хүлээгээгүй заавал биелүүлэх үүрэг оршин байж болох юм. Гэхдээ төсөвт тусгагдаагүй байх нь одоогийн үүрэг үүсээгүй гэсэн утгыг дангаараа илэрхийлэхгүй.

5.26 Хэдийгээр улсын секторын байгууллага нь нөөцийг гадагш зарцуулах хуулиар хүлээсэн үүрэггүй боловч ингэж татгалзсаны эдийн засгийн болон улс төрийн үр дагавар нь нөөцийн гадагш зарцуулалтаас тухайн байгууллагыг зайлсхийх бодит боломжгүй буюу боломж багатай болгох тийм нөхцлийг “эдийн засгийн дарамт шахалт”, “улс төрийн шаардлага” буюу бусад нөхцөл байдлаар үүсгэж болох юм. Эдийн засгийн дарамт шахалт, улс төрийн шаардлага буюу бусад нөхцөл байдал нь хуулиар хүлээгээгүй заавал биелүүлэх үүргээс өр төлбөр үүсэхэд хүргэж болно.

## **Цэвэр санхүүгийн байдал, бусад нөөц ба бусад үүрэг**

- 5.27 5.4-р параграфт тайлбарласанчлан, санхүүгийн тайлагналын зорилтуудыг хангахын тулд УСНББОУСЗ нь Онолын үзэл баримтлалд заасан, элементийн тодорхойлолтыг хангахгүй тийм нөөц буюу үүргийг зарим тохиолдолд санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөх шаардлагатай гэж УСНББОУС-ыг боловсруулах буюу хянан засварлах үедээ тодорхойлж болох юм. Ийм тохиолдолд УСНББОУС нь тэдгээр нөөц буюу үүргийг энэхүү Үзэл баримтлалд тодорхойлсон зургаан элементийн нэмэлт зүйл болох Бусад нөөц эсвэл Бусад үүрэг гэж хүлээн зөвшөөрөхийг шаардах буюу зөвшөөрч болно.
- 5.28 Цэвэр санхүүгийн байдал нь санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрсөн бусад нөөцийг нэмж, бусад үүргийг хассаны дараах хөрөнгө ба өр төлбөрийн хоорондох зөрүү юм. Цэвэр санхүүгийн байдал нь эерэг эсвэл сөрөг үлдэх дүнтэй байж болно.

## **Орлого ба зардал**

### **Тодорхойлолт**

- 5.29 Орлого гэдэг нь:

*Өмчлөлийн хувь оролцооноос үүссэн нэмэгдэлтээс бусад байдлаар тухайн байгууллагын цэвэр санхүүгийн байдалд гарсан өсөлт юм.*

- 5.30 Зардал гэдэг нь:

*Өмчлөлийн хуваарилалтаас үүссэн багасалтаас бусад байдлаар тухайн байгууллагын цэвэр санхүүгийн байдалд гарсан бууралт юм.*

- 5.31 Орлого ба зардал нь арилжааны болон арилжааны бус ажил гүйлгээ, хөрөнгө ба өр төлбөрийн үнэ цэнийн хэрэгжээгүй өсөлт болон бууралт, элэгдлээр дамжин гарах хөрөнгийн ашиглан зарцуулалт, үнэ цэнийн бууралтаар дамжин илэрхийлэгдэх үйлчилгээний чадавхийн болон эдийн засгийн үр өгөөж бий болгох чадварын багасалт гэх мэт бусад үйл явдлуудаас үүсдэг. Орлого ба зардал нь бие даасан ажил гүйлгээнээс эсвэл ажил гүйлгээнүүдийн бүлгээс үүсэж болно.

## **Тайлант үеийн ашиг, алдагдал**

- 5.32 Байгууллагын тайлант үеийн ашиг, алдагдал нь санхүүгийн үр дүнгийн тайланд тайлагнасан орлого ба зардлын хоорондох зөрүү юм.

## Өмчлөлийн хувь оролцоо ба өмчлөлийн хуваарилалт

### Тодорхойлолт

5.33 Өмчлөлийн хувь оролцоо гэдэг нь:

*Эзэд болохын хувьд өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд гаднын талуудаас оруулсан бөгөөд байгууллагын цэвэр санхүүгийн байдал дахь хувь оролцоог тогтоох буюу нэмэгдүүлэх тухайн байгууллагад орох нөөцийн орлогын гүйлгээ юм.*

5.34 Өмчлөлийн хуваарилалт гэдэг нь:

*Эзэд болохын хувьд тэдний бүрэн эрхийн хүрээнд гаднын талуудад хуваарилсан бөгөөд байгууллагын цэвэр санхүүгийн байдал дахь хувь оролцоог буцаах буюу багасгах тухайн байгууллагаас гарах нөөцийн зарлагын гүйлгээ юм.*

5.35 Эздээс оруулах нөөцийн орлогын гүйлгээ, үүн дотроо өмчлөлийн хувь оролцоог анх тогтоох орлогын гүйлгээ, түүнчлэн эзэд болохын хувьд тэдний бүрэн эрхийн хүрээнд эздэд олгох нөөцийн зарлагын гүйлгээг орлого, зардлаас ялган авч үзэх нь чухал ач холбогдолтой байдаг. Хийгдэж болох нөөцийн хувь оруулалт ба ногдол ашгийн төлбөрөөс гадна хөрөнгө, өр төлбөрийг улсын секторын байгууллагуудын хооронд шилжүүлэх нь зарим улс орны хувьд харьцангуй нийтлэг байдаг. Ийм шилжүүлэг нь өмчлөлийн хувь оролцоо болон өмчлөлийн хуваарилалтын тодорхойлолтыг хангах тохиолдолд тэдгээрийг ийм байдлаар тайлагнана.

5.36 Өөр нэг байгууллага нь үйл ажиллагааг эхлэн явуулах хүчин чадлаар шинэ байгууллагыг хангахын тулд нөөцөөр хувь оруулсан тохиолдолд уг шинэ байгууллагын үүсгэн байгуулалтаар өмчлөлийн хувь оролцоо үүсэж болох юм. Улсын секторын хувьд, байгууллагад оруулсан хувь оролцоо болон тухайн байгууллагаас хийгдсэн хуваарилалт нь зарим тохиолдолд засгийн газрын бүтцийн өөрчлөлттэй холбоотой бөгөөд мөнгөн ажил гүйлгээ биш, харин хөрөнгө, өр төлбөрийн шилжүүлэг хэлбэртэй байдаг. Өмчлөлийн хувь оролцоо нь өмчийн хэрэглүүрээр батлан илэрхийлэх боломжгүй янз бүрийн хэлбэртэй байж болно.

5.37 Өмчлөлийн хувь оролцоо нь тухайн байгууллагыг үүсгэн байгуулах үеийн нөөцийн анхны хувь оруулалт эсвэл нөөцийн дараагийн тайлант үеийн оруулалт, үүн дотроо байгууллагын бүтцийн өөрчлөлтийн үеийн хувь оруулалт хэлбэртэй байж болно. Өмчлөлийн хуваарилалт нь: (а) хөрөнгө оруулалтын өгөөж; (б) хөрөнгө оруулалтын бүрэн буюу хэсэгчилсэн буцаалт; эсвэл (в) тухайн байгууллагыг татан буулгах буюу бүтцийн өөрчлөлт хийх тохиолдолд аливаа үлдэх нөөцийн буцаалт хэлбэртэй байж болно.

## Дүгнэлтийн үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь Онолын Үзэл Баримтлалыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### Бүлгийн цар хүрээ

ДҮ5.1. “Элементүүд ба Санхүүгийн Тайлан дахь Хүлээн Зөвшөөрөлт” гэсэн Зөвлөлдөх Баримт Бичиг (Зөвлөлдөх баримт бичиг)-т хариулт ирүүлсэн хүмүүс нь Үзэл баримтлалын энэхүү үе шатанд яагаад УСНББОУСЗ нь зөвхөн санхүүгийн тайлангийн элементүүдийг авч үзэж буй эсэхийг асуусан. УСНББОУСЗ нь санхүүгийн тайлангаас гадна, санхүүгийн тайлагналын илүү өргөн хүрээтэй талбарт эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийн хувьд элементүүдийг бас боловсруулах хэрэгтэй гэдгийг тэд санал болгож байсан. УСНББОУСЗ нь энэхүү үзэл бодлын ач холбогдол болон ийм элементүүдийг ирээдүйд боловсруулах хэрэгцээ шаардлагыг хүлээн зөвшөөрсөн. Гэвч санхүүгийн тайлангийн стандарт тогтоох өөрийн ирээдүйн үйл ажиллагааны найдвартай ба ил тод, ойлгомжтой суурийг бүрдүүлэхийн тулд УСНББОУСЗ нь санхүүгийн тайлангийн элементүүдийн боловсруулалтыг эхлээд авч үзэх нь чухал ач холбогдолтой гэж үзсэн.

ДҮ5.2. УСНББОУСЗ нь мөнгөн орлогын гүйлгээ ба мөнгөн зарлагын гүйлгээг мөнгөн гүйлгээний тайлангийн элементүүд гэж тодорхойлох хэрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Мөнгөн орлогын гүйлгээ ба мөнгөн зарлагын гүйлгээ нь энэ Бүлэгт тодорхойлсон элементүүдийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд стандартын түвшинд цаашид нэмэлт заавар удирдамжаар хангах хэрэгтэй гэсэн байр суурийг УСНББОУСЗ баримталдаг.

### Хөрөнгө

#### *Нөөц*

ДҮ5.3. Нөөц нь үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөжийг бий болгох чадвар хэлбэрээр байгууллагыг өгөөжөөр хангадаг. Нөөцийн шинж төрлийн талаархи өөрийн дүгнэлтүүдийг гаргахдаа УСНББОУСЗ нь нөөц оршин байхын тулд тухайн нөөцийн үр өгөөж уг байгууллагад аль хэдийн орсон байх ёстой эсэхийг харгалзан үзсэн. Гэвч нөөц нь өөртөө өгөөжийг агуулдаг бөгөөд тэрхүү өгөөжийн эрхийг хянадаг байгууллага нь өгөөжид хандан нэвтэрч чадна гэж УСНББОУСЗ дүгнэсэн. УСНББОУСЗ нь өгөөжийн шинж төрөл (ДҮ5.7 ба ДҮ5.8-р параграфыг үзнэ үү) ба хяналтыг (ДҮ5.9-ДҮ5.14-р параграфыг үзнэ үү) мөн харгалзан үзсэн.

#### *Нөхцөлт бус эрх ба Бүрэн биелэгдээгүй гэрээ*

ДҮ5.4. Нөөцийн нөхцөлт бус эрх нь ирээдүйд тухайн байгууллагыг нөөцөөр хангахыг шаарддаг гэрээ буюу бусад заавал биелүүлэх хэлцлээс ихэвчлэн үүсдэг. УСНББОУСЗ нь ийм маш олон тооны эрх байдгийг тэмдэглэсэн бөгөөд өнгөрсөн үйл явдлын үр дүн байдлаар байгууллагын хяналтандаа авсан үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөж бий болгох

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

чадварыг илэрхийлэх нөхцөлт бус эрхүүд нь хөрөнгө үүсэхэд хүргэнэ гэдгийг онцлон дурдсан. Ийм хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт нь уг хүлээн зөвшөөрөлтийн шалгуур хангагдах эсэхээс хамаардаг. Хөрөнгийн тодорхойлолтыг нөхцөлт бус эрхэд мөрдсөний үр дагаврыг стандартын түвшинд авч үзэх хэрэгтэй гэж УСНББОУСЗ дүгнэсэн.

ДҮ5.5. Бүрэн биелэгдээгүй гэрээ нь нөөцийг хүлээн авах нөхцөлт бус эрхтэй ба ирээдүйд нөгөө талд нөөцийг шилжүүлэх тэнцүү дүн бүхий одоогийн үүрэгтэй байх үеийн заавал биелүүлэх хэлцэл юм. Улсын секторын байгууллагууд нь ийм маш олон тооны хэлцэлд оролцох магадлалтай байдаг. Байгууллага нь нөөцийг хүлээн авах эрхтэй ба нөөцийг зарцуулахаас зайлсхийх бодит боломжгүй одоогийн үүрэгтэй байх тул ийм хэлцэл нь хөрөнгө болон өр төлбөрийн аль алиныг үүсэхэд хүргэж болох юм гэсэн байр суурийг УСНББОУСЗ илэрхийлсэн.

ДҮ5.6. Бүрэн биелэгдээгүй гэрээний дагуу хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх нь санхүүгийн байдлын тайлан болон санхүүгийн үр дүнгийн тайланд боломжит маш их үнийн дүнтэй хөрөнгө, өр төлбөрийг тусгахтай холбоотой байдаг бөгөөд энэ нь ойлгомжтой байх чанарын шинжүүдтэй зөрчилдөж болох юм гэсэн байр суурийг УСНББОУСЗ мөн илэрхийлсэн. Бүрэн биелэгдээгүй гэрээний эрх, үүргээс хөрөнгө ба өр төлбөр үүсэх эсэхийг Онолын үзэл баримтлалд заасан, элементүүдийн тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг тэдгээр эрх, үүрэг хангах эсэх үнэлгээгээр тодорхойлдог. Ийм үнэлгээ, түүнчлэн бүрэн биелэгдээгүй гэрээнээс үүсэх аливаа элементүүдийн санхүүгийн тайлан дахь толилуулгын арга хандлагыг стандарт түвшинд авч үздэг.

*Үйлчилгээний чадавхи ба эдийн засгийн үр өгөөж*

ДҮ5.7. Байгууллагын зорилтуудад нийцсэн үйлчилгээ үзүүлэх хөрөнгийн чадварыг тодорхойлохын тулд “үйлчилгээний чадавхи” гэсэн нэр томъёог ашигласан. Цэвэр мөнгөн орлогын гүйлгээ бий болгох хөрөнгийн чадварыг тусгахын тулд “эдийн засгийн үр өгөөж” гэсэн нэр томъёог ашигладаг. Эдийн засгийн үр өгөөжид үйлчилгээний чадавхи хамаарна гэж зарим хүмүүс үздэг. Өөр зарим хүмүүс нь үйлчилгээний чадавхид эдийн засгийн үр өгөөж хамаарна гэж үздэг, түүнчлэн эдгээр нэр томъёог харилцан шилжих утгатайгаар хэрэглэж болно гэсэн байр суурь бас байдаг. Үйлчилгээний чадавхи ба эдийн засгийн үр өгөөжийг бий болгох чадварын аль алиныг илэрхийлэх хэллэгийг нөөцийн тайлбарт тусган оруулах хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ авч үзсэн.

ДҮ5.8. Зөвлөлдөх Баримт Бичиг болон Саналын Төсөлд хариулт ирүүлсэн олон хүмүүс нь улсын секторын ихэнх байгууллагуудын үйлчилгээ үзүүлэх зорилтын улмаас үйлчилгээний чадавхи гэсэн тусгай хэллэгийг хөрөнгийн шинж чанар байдлаар тусган оруулахыг дэмжсэн гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Иймээс нөөцийн тайлбарт “үйлчилгээний чадавхи” ба “эдийн засгийн үр өгөөж” гэсэн нэр томъёоны аль алиныг оруулах хэрэгтэй гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Улсын секторын ихэнх байгууллагуудын үндсэн зорилт нь үйлчилгээ үзүүлэх явдал боловч улсын секторын байгууллагууд

## УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

нь мөн цэвэр мөнгөн орлогын гүйлгээ бий болгох цор ганц зорилготойгоор үйл ажиллагааг эрхлэн явуулж болно гэдгийг энэ арга хандлагад зөвшөөрдөг.

### Хяналт

ДҮ5.9. Хяналт нь хөрөнгийн чухал шинж чанар эсэх, эсвэл бусад үзүүлэлтүүдийг, үүн дотроо дараах зүйлсийг хөрөнгийн чухал шинж чанар гэж тодорхойлох хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн:

- Хууль ёсны өмчлөл;
- Нөөцөд хандан нэвтрэх эсвэл нөөцөд гаднын талуудад хандан нэвтрэхийг хязгаарлах буюу хориглох эрх;
- Байгууллагын зорилтуудад хүрэхийн тулд нөөцийг ашигладаг эсэхийг ханган магадлах арга хэрэгсэл;
- Нөөцөөс үүсэх үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөжийг хүртэх хууль ёсны хүчин төгөлдөр эрхийн оршин байдал.

Хяналт оршин буй эсэхийг үнэлэхийн тулд шүүн тунгаалт хийх шаардлагатай учраас зарим тохиолдолд хяналтыг мөрдөхөд төвөгтэй байж болох юм гэж үздэг хүмүүсийн байр суурийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрдөг. Түүнчлэн, хяналтыг тухайн нөөцөөс бий болох бие даасан өгөөжид бус, харин нөөцөд бүхэлд нь буруу хэрэглэж болох юм. Гэвч хяналтын оршин байдал нь тухайн байгууллага ба хөрөнгийн хоорондох харилцан холбоог хялбарчилж өгдөг учраас УСНББОУСЗ нь ийм хүндрэлтэй байдлыг үл харгалзан хяналт бол хөрөнгийн чухал шинж чанар юм гэж дүгнэсэн.

ДҮ5.10. Үл хөдлөх хөрөнгө, тоног төхөөрөмж гэх мэт нөөцийн хууль ёсны өмчлөл нь хөрөнгийн үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөжийг хүртэх нэг арга зам юм. Гэвч үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөжийг бий болгох чадварыг ашиглах эрх нь тухайн суурь нөөцийн хувьд хууль ёсны өмчлөлгүй үед ч оршин байж болох юм. Жишээлбэл; үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөж бий болгох чадварыг түрээслэсэн хөрөнгийн эзэмшилт, ашиглалтаар дамжуулан ашиглах эрхийг тэрхүү түрээслэсэн хөрөнгийн хууль ёсны өмчлөлгүйгээр үнэлдэг. Иймээс нөөцийн хууль ёсны өмчлөл нь хөрөнгийн чухал шинж чанар биш юм. Гэвч хууль ёсны өмчлөл нь хяналтыг илгэх үзүүлэлт юм.

ДҮ5.11. Нөөцөд хандан нэвтрэх эрх нь дараах зүйлсийг тодорхойлох боломжийг байгууллагад олгож болох юм:

- Өгөөж хүртэгчдэд үйлчилгээ үзүүлэхийн тулд уг нөөцийн үйлчилгээний чадавхийг шууд ашиглах эсэх;
- Нөөцийг мөнгө гэх мэт өөр хөрөнгөөр арилжих эсэх;
- Үйлчилгээ үзүүлэх буюу эдийн засгийн үр өгөөж бий болгох бусад аливаа арга замаар хөрөнгийг ашиглах эсэх.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

- ДҮ5.12. Нөөцөд хандан нэвтрэлт нь чухал ач холбогдолтой бөгөөд хөрөнгө бий болоход хүргэдэггүй боловч байгууллага хандан нэвтрэдэг агаар гэх мэт нөөцүүд байдаг. Иймээс нөөцөд хандан нэвтрэх чадвар нь тухайн нөөцөд бусад талуудын хандан нэвтрэлтийг хориглох буюу хязгаарлах чадвараар дэмжигдсэн байх ёстой. Жишээлбэл; (а) байгууллага нь музейд орох хураамжийг тогтоох эсэхийг шийдвэрлэх ба хураамж төлөөгүй хүмүүс хандан нэвтрэхийг хязгаарлаж болох юм, (б) засгийн газар нь өөрийн газар доорх байгалийн баялагийг хянах ба бусад этгээд хандан нэвтрэхийг хязгаарладаг байж болно. Авто замыг ашиглах эрх, ашигт малтмалын зорилгоор талбарт хайгуул хийх эрх гэх мэт тодорхой нөөцийн хууль ёсны хүчин төгөлдөр эрх нь түүний эзэмшигчийн хувьд хөрөнгийг төлөөлөн илэрхийлж болох юм. Гэвч байгууллага нь нөөцтэй холбоотой үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөж бий болгох чадварын хувьд хууль ёсны эрх шаардахгүй тийм арга замаар хандан нэвтрэх боломжтой байж болно. ДҮ5.9-р параграфт тодорхойлсон хүчин зүйлс нь хөрөнгийн тодорхойлолтын чухал шинж чанар биш, харин хяналтын оршин байдлын үзүүлэлт байх магадлалтай гэж УСНББОУСЗ үздэг.
- ДҮ5.13. Эдийн засгийн өмчлөлийн хандлага нь хяналтын арга хандлагын боломжит хувилбар мөн эсэхийг УСНББОУСЗ нь бас авч үзсэн. Эдийн засгийн өмчлөлийн хандлага нь тухайн байгууллагын хөрөнгийн үнэ цэнэд хувь нэмрээ оруулдаг эдийн засгийн суурь шинжүүдийн улмаас байгууллагад учрах эрсдэлд голлон чиглэдэг. “*Элементүүд ба Санхүүгийн Тайлан дахь Хүлээн Зөвшөөрөлт*” гэсэн Саналын Төсөлд хариулт ирүүлсэн бөгөөд хяналтын арга хандлагыг дэмждэг зарим хүмүүс нь эдийн засгийн өмчлөлийн арга хандлагын нарийн төвөгтэй байдлын талаар саналаа илэрхийлсэн. Эдийн засгийн өмчлөлийн хандлага нь субъектив бөгөөд хэрэгжихэд төвөгтэй гэж УСНББОУСЗ дүгнэсэн бөгөөд иймээс энэхүү арга хандлагаас татгалзсан.
- ДҮ5.14. Өмчлөлийн эрсдэл ба урамшууллын шинжилгээ нь хяналтын ач холбогдолтой үзүүлэлт эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн. Хяналтын арга хандлага нь нөөцөд агуулагдаж буй үйлчилгээний чадавхи ба/буюу эдийн засгийн үр өгөөж бий болгох чадвараас өгөөж хүртэхийн тулд уг нөөцийг хэрхэн ашиглах талаар удирдан чиглүүлэх тухайн байгууллагын бүрэн эрхэд голлон чиглэдэг. Харин эрсдэл ба урамшууллын арга хандлага нь тухайн байгууллагад бий болох хөрөнгийн үнэ цэнэ болон холбогдох эрсдэлд хувь нэмрээ оруулах эдийн засгийн суурь шинжүүдийн улмаас байгууллагад учрах эрсдэлд голлон чигэлдэг. Тодорхой ажил гүйлгээ, үйл явдалтай холбоотой эрсдэл ба урамшуулал, түүнчлэн аливаа ажил гүйлгээ буюу үйл явдлын аль тал нь тэдгээр эрсдэл, урамшууллын ихэнхийг хэсгийг хариуцаж буй эсэх нь тухайн ажил гүйлгээ болон үйл явдлын оролцогч талуудын хянаж байгаа хөрөнгийн шинж төрлийг тодорхойлоход хамааралтай бөгөөд ач холбогдолтой байж болох юм. Энэ нь тухайн тодорхой талуудын эдийн засгийн эрх, үүргийг хэрхэн тооцоолж, тэдгээрт хамааруулах эсэхийг тодорхойлоход мөн ач холбогдолтой байж болно. Гэвч энэ нь хөрөнгийг хянаж буй талыг дангаараа илэрхийлэхгүй. Иймээс УСНББОУСЗ нь өмчлөлийн эрсдэл ба урамшууллыг хяналтын үзүүлэлт байдлаар тусган оруулахгүй байхаар шийдвэрлэсэн.



УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

*Өнгөрсөн үйл явдал*

ДҮ5.15. Хөрөнгө үүсэхэд хүргэж буй өнгөрсөн ажил гүйлгээ буюу бусад үйл явдлын тогтоолт нь тухайн хөрөнгийн тодорхойлолтын чухал шинж чанар байвал зохино гэж Зөвлөлдөх Баримт Бичиг болон Саналын Төсөлд хариулт ирүүлсэн зарим хүмүүс үзэж байсан. Өнгөрсөн үйл явдлын тодорхойлолт нь зайлшгүй шаардлагатай биш, иймээс чухал шинж болохгүй гэсэн байр суурийг өөр зарим хүмүүс илэрхийлсэн. Ийм шаардлага нь хөрөнгө үүсэхэд хүргэсэн өнгөрсөн үйл явдлыг олж тогтооход хэт их ач холбогдол өгнө гэж тэд үзэж байсан. Ингэж ач холбогдол өгөх нь тайлангийн өдрөөр нөөцийн хувьд эрх оршин байсан эсэх гэсэн илүү чухал асуудлын оронд, аль үйл явдал нь нөлөөлөх үйл явдал талаар будлиан үүсгэж, маргаан гарахад хүргэж болох юм. Ийм байр суурьтай байсан хүмүүс нь хөрөнгийн чухал шинж чанар бол нөөцийн оршин байдал юм гэж үзэж байсан. Өнгөрсөн үйл явдал нь хөрөнгийн оршин байдлыг дэмжих ач холбогдолтой нотолгоогоор хангах боловч чухал шинж чанар биш гэдгийг зарим хүмүүс хүлээн зөвшөөрсөн.

ДҮ5.16. Хариулт өгсөн олон хүмүүс нь хөрөнгийн тодорхойлолтын чухал шинж чанар байдлаар өнгөрсөн үйл явдлыг тодорхойлох хэрэгтэй гэсэн байр суурьтай байсан. Эдгээр хариулт өгсөн хүмүүстэй, ялангуяа улсын секторын олон хөтөлбөр ба үйл ажиллагааны нарийн төвөгтэй байдал нь нөөцийн хяналт үүсэж болох олон агшинтай байдаг гэдэгтэй УСНББОУСЗ санал нийлсэн. Иймээс зохих өнгөрсөн үйл явдлыг тодорхойлох нь хөрөнгийн оршин байдлыг тогтооход чухал ач холбогдолтой гэж УСНББОУСЗ дүгнэсэн.

ДҮ5.17. Засгийн газрын эрх ба бүрэн эрх нь хөрөнгийг тодорхойлолтод ихээхэн чухал ач холбогдолтой байдаг. Татвар ногдуулах, тусгай зөвшөөрөл олгох, түүнчлэн цахилгаан соронзон орон гэх мэт биет бус нөөцөд агуулагдаж буй үр өгөөжид хандан нэвтрэх, эсвэл хандан нэвтрэлтийг хязгаарлах буюу хориглох бүрэн эрх нь онцгой бүрэн эрхийн жишээ юм. Ийм бүрэн эрх нь тухайн байгууллагын нөөц ба хөрөнгө болох эрхийг хэзээ үүсгэх эсэхийг тодорхойлоход ихэвчлэн төвөгтэй байдаг.

ДҮ5.18. Тухайлбал; татвар, хураамж ногдуулах эрхийг тогтоох засгийн газрын бүрэн эрх нь тухайн засгийн газарт эдийн засгийн үр өгөөж ороход эцэстээ хүргэх дэс дараалсан үйл явдлуудыг ихэвчлэн эхлүүлдэг. Татвар, хураамж ногдуулах засгийн газрын эрх ба бүрэн эрхээс хөрөнгө хэзээ үүсэх талаархи хоёр үзэл бодлыг УСНББОУСЗ авч үзсэн. Эхний үзэл бодлын дагуу, засгийн газар нь тайлангийн өдөр бүрээр татвар ногдуулах угийн бүрэн эрхтэй бөгөөд иймээс татвар, хураамж ногдуулах ерөнхий чадвар нь хөрөнгө юм. Ийм хөрөнгө нь үнэн зөв төлөөлөх хэмжилтийн чадвартай байх магадлал багатай гэдгийг энэхүү үзэл бодлыг дэмжигчид хүлээн зөвшөөрдөг боловч засгийн газар нь байнгын хөрөнгөтэй гэсэн мэдэгдлээс энэ нь гажих ёсгүй гэж үздэг. Харин нөгөө үзэл бодлын дагуу, татвар ба хураамж ногдуулах бүрэн эрхийг хууль ёсны арга замаар эрх болгон хөрвүүлэх ёстой бөгөөд хөрөнгийг бий болгохын тулд ийм эрхийг хэрэгжүүлдэг буюу хэрэгжүүлэх боломжтой байх ёстой. Зөвлөлдөх Баримт

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Бичиг болон Саналын Төсөлд хариулт ирүүлсэн олон хүмүүс нь энэхүү сүүлийн үзэл бодлыг дэмжсэн. УСНББОУСЗ нь эдгээр хариулт өгсөн хүмүүстэй санал нийлж байна. Тухайлбал; засгийн газрын угийн бүрэн эрх нь хэрэгжих хүртлээ ба үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөжийг хүлээн авах эрх оршин байх хүртэл хөрөнгө үүсэхэд хүргэхгүй гэж УСНББОУСЗ дүгнэсэн.

## Өр төлбөр

### *Одоогийн үүрэг*

ДҮ5.19. Үүрэг нь хэзээ одоогийн үүрэг болох эсэхийг авч үзэхдээ, УСНББОУСЗ нь хуулиар хүлээсэн үүргээр одоогийн үүрэг үүснэ гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Зарим улс оронд, улсын секторын байгууллагууд нь эрх зүйн зарим хэлцэл хийхийг зөвшөөрдөггүй боловч одоогийн үүрэг үүсэхэд хүргэдэг адилтгах механизм байдаг. Ийм механизмыг хуулийн дагуу заавал биелүүлэх гэж үздэг. Хуулиар хүлээгээгүй үүргийг хэрхэн ангилах эсэхийг УСНББОУСЗ нь үүний дараа авч үзсэн. “Гэрээний бус үүрэг” нь стандарт тогтоох олон улсын ном бүтээлд тусгагдсан нэр томъёо бөгөөд УСНББОУС-д үүнийг ашигласан гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Гэвч улсын секторын хүрээнд үүнийг хэрэглэх ба тайлбарлахад төвөгтэй гэж үздэг. Иймээс УСНББОУСЗ нь адилтгах томъёололыг тухайлбал, “нийгмийн буюу ёс суртахууны үүрэг эсвэл шаардлага” гэсэн нэр томъёог харгалзан үзсэн. “Нийгмийн” гэсэн хэллэгийг улс төрийн үнэт зүйлстэй андуурах, “ёс суртахууны үүрэг” гэсэн нэр томъёо нь стандарт тогтоогчид ба тайлан бэлтгэгчдийг ёс суртахууны шүүгчид гэж ойлгуулах эрсдэл гэдэгт УСНББОУСЗ нь санаа зовж буйгаа илэрхийлсэн. Иймээс “хуулиар хүлээсэн заавал биелүүлэх үүрэг” ба “хуулиар хүлээгээгүй заавал биелүүлэх үүрэг”-ийг ялган тодорхойлох нь хамгийн хялбар бөгөөд ойлгомжтой арга хандлага гэж УСНББОУСЗ дүгнэсэн. “Хуулиар хүлээгээгүй заавал биелүүлэх үүрэг” гэсэн нэр томъёо нь үүргийг илэрхийлнэ гэж тайлбарлаж болох бөгөөд ингэснээр түүний хууль ёсны байдал эргэлзээтэй болно гэсэн байр суурийг УСНББОУСЗ харгалзан үзсэн ба энэ санааг үгүйсгэсэн. ДҮ5.30-ДҮ5.34-р параграфт хуулиар хүлээгээгүй заавал биелүүлэх үүргийг авч хэлэлцсэн бөгөөд Онолын үзэл баримтлалын зорилгын хувьд тэдгээрийн утгыг тайлбарласан.

ДҮ5.20. “Нөхцөлт” ба “нөхцөлт бус” үүрэг, “гүйцэтгэхэд бэлэн үүрэг”, “гүйцэтгэлийн үүрэг” нь одоогийн үүрэг байж болох эсэхийг УСНББОУСЗ нь одоогийн үүргийн хүрээнд авч үзсэн.

### *Нөхцөлт ба Нөхцөлт бус үүрэг*

ДҮ5.21. Нөхцөлт бус үүрэг нь ирээдүйн үйл явдлаас хамаарахгүй бие даасан үүрэг юм. Хэрэв өр төлбөрийн тодорхойлолтыг хангаж байвал нөхцөлт бус үүрэг нь өр төлбөр үүсэхэд хүргэнэ. Нөхцөлт үүрэг нь тухайн тайлагнагч байгууллагын хяналтанд буй эсвэл хяналтанд байхгүй байж болох ирээдүйн үйл явдлын боломжит гарч тохиолдолтыг агуулдаг. Нөхцөлт үүрэг нь Онолын үзэл баримтлалд тодорхойлсончлон, өр төлбөр үүсэхэд хүргэх

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

боломжтой гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Нөхцөлт үүрэг нь өр төлбөрийн тодорхойлолтыг хангах эсэхийг тодорхойлохдоо, тухайн үүргийн шинж төрөл болон түүний үүссэн нөхцөл байдлыг харгалзан үздэг. Улсын секторын хөтөлбөр ба үйл ажиллагааны нарийн цогц байдлыг харгалзан үзвэл, тухайн байгууллага нөөцийг гадагш зарцуулахаас зайлсхийх бодит боломжгүй буюу боломж багатай болоход хүргэх өнгөрсөн үйл явдал (буюу үйл явдлууд)-ыг олж тогтоох нь ихэвчлэн хялбар бус байж болох юм. Тодорхой хэлцэл буюу нөхцөл байдалд оршин буй нөхцөлт үүргүүд нь Онолын үзэл баримтлалд заасан, тодорхойлолттой нийцэх өр төлбөр үүсэхэд хүргэж болох эсэх талаархи заавар удирдамж нь стандартын түвшний асуудал юм.

ДҮ5.22. Тухайн нөхцөл байдал дахь нөхцөлт үүргээс үүсэх буюу түүнтэй холбоотойгоор оршин байж болох одоогийн үүргийг тодорхойлохын тулд янз бүрийн нэр томъёог ашигладаг. Үүнд: гүйцэтгэхэд бэлэн үүрэг ба гүйцэтгэлийн үүрэг хамаарна. Эдгээр үүргийн шинж чанарууд болон Онолын үзэл баримтлалын хүрээнд УСНББОУСЗ-ийн гаргасан дүгнэлтүүдийг доор дурдсан болно.

*Гүйцэтгэхэд бэлэн үүрэг*

ДҮ5.23. Гүйцэтгэхэд бэлэн үүрэг нь нөхцөлт үүргийн нэг хэлбэр юм. Гүйцэтгэхэд бэлэн үүрэг нь байгууллагын хяналтаас гадуурх тусгайлан заасан ирээдүйн үйл явдал гарч тохиолдвол (эсвэл гарч тохиолдохгүй бол) тэрхүү үүргийг гүйцэтгэх бэлтгэлтэй байхыг уг байгууллагаас шаарддаг. Даатгалтай холбоотой гэх мэт гэрээний тодорхой нөхцөл, мөнгөн алдагдалтай үүсмэл гэрээ гэх мэт зарим санхүүгийн хэрэглүүр, түүнчлэн тусгайлан заасан ирээдүйн үйл явдал гарч тохиолдвол (эсвэл гарч тохиолдохгүй бол) байгууллага нь нөөцийг шилжүүлэх үүрэг бүхий баталгаа зэргийн хувьд үүсэж болох өр төлбөрийг илэрхийлэхийн тулд энэхүү гүйцэтгэхэд бэлэн үүрэг гэсэн нэр томъёог ашигладаг. Төлбөрийг чухам хэнд төлөх нь ерөнхийдөө мэдэгдэхгүй байлаа ч гэсэн ийм тохиолдолд тодорхойлж болох өнгөрсөн үйл явдал байх бөгөөд тухайн байгууллагаас нөөцийг гадагш зарцуулж болох юм.

ДҮ5.24. Гүйцэтгэхэд бэлэн үүргийн талаархи хэлэлцүүлгийг Зөвлөлдөх Баримт Бичигт тусгасан. Хариулт ирүүлсэн олон хүмүүс нь гүйцэтгэхэд бэлэн үүрэг ба нөхцөлт бусад үүргийн хоорондох ялгаа тодорхойгүй байна гэж үзсэн. Гүйцэтгэхэд бэлэн үүрэг гэсэн нэр томъёог улсын секторт түгээмэл ашигладаггүй бөгөөд улсын секторын зарим нөхцөл байдалд тийм ч сайн тохирдоггүй болохыг Саналын Төсөлд тайлбарласан ба гүйцэтгэхэд бэлэн үүргээр өр төлбөр үүсэхэд хүргэх эсэх нь стандартын түвшний асуудал гэж үзсэн. Хариулт өгсөн зарим хүмүүс нь Саналын Төсөлд дурдсан тайлбартай санал нийлэхгүй байсан бөгөөд гүйцэтгэхэд бэлэн үүрэг нь зарим нөхцөл байдалд өр төлбөр үүсгэж болох эсэх талаархи стандартын түвшинд ашиглаж болох заавар удирдамжийг Онолын үзэл баримтлалд тусгах хэрэгтэй гэсэн байр суурийг илэрхийлсэн.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

ДҮ5.25. Ирээдүйд гарч тохиолдож болох тодорхой нөхцөл байдалд нөөцийг өөр байгууллагад шилжүүлэх улсын секторын байгууллагын үүрэгт тухайлбал, хамгийн эцсийн найдлага тавих боломжит зээлдүүлэгчийн үүрэг, түүнчлэн өргөн хүрээтэй нийгмийн үйлчилгээ үзүүлэх хөтөлбөрийн дэмжлэг хамаарна. Эдгээр нөхцөл байдалд нөөцийг өөр байгууллагад шилжүүлэх үүргийн оршин байдал нь засгийн газар ба улсын секторын байгууллагаас хамааран өөрчлөгдөх янз бүрийн ач холбогдол болон шинж төрөл бүхий олон нөхцөл байдлын цаашдын биелэлтээс шалтгаалж болох юм. Хөтөлбөрийн нөхцлийн дагуу нөөцийг бусад талуудад шилжүүлэх уг улсын секторын байгууллагын үүргийн үр дагавар байдлаар өр төлбөр үүсэх нөхцөл байдал, түүнчлэн тэрхүү өр төлбөрийг хэрхэн тодорхойлж, тайлагнах эсэхийг Онолын үзэл баримтлалд заасан зарчмуудад нийцүүлэн стандартын түвшинд авч үзэх хэрэгтэй гэсэн байр суурийг УСНББОУСЗ илэрхийлсэн. Гүйцэтгэхэд бэлэн гэж ангилж болох бүх үүрэг нь өр төлбөрийн тодорхойлолтыг хангах эсэхийг Онолын үзэл баримтлалд зааж болохгүй гэж УСНББОУСЗ шийдвэрлэсэн. Мөн УСНББОУСЗ нь “гүйцэтгэхэд бэлэн үүрэг” гэсэн нэр томъёог Онолын үзэл баримтлалд ашиглахгүй байхаар шийдвэрлэсэн.

*Гүйцэтгэлийн үүрэг*

ДҮ5.26. Гүйцэтгэлийн үүрэг нь байгууллага ба гаднын талын хооронд байгуулсан бөгөөд тэрхүү нөгөө талд нөөцийг шилжүүлэх гэрээний буюу бусад заавал биелүүлэх хэлцлийн үүрэг юм. Гүйцэтгэлийн үүргийг гэрээ буюу бусад хэлцэлд ихэвчлэн шууд тодорхой заадаг. Гүйцэтгэлийн бүх үүрэг нь шууд тодорхой байдаггүй. Жишээлбэл; хууль дүрмийн шаардлага нь улсын секторын байгууллагын гүйцэтгэлийн шууд бус үүрэг бөгөөд гэрээ, хэлцлийн нөхцлийн нэмэлт шинжтэй байдаг.

ДҮ5.27. Байгууллага нь төлбөр авах ба хариуд нь, засгийн газрын хөрөнгө ашиглах эрхийг уг гаднын талд олгох хэлцэл хийсэн тохиолдолд мөн гүйцэтгэлийн үүрэг үүсдэг. Үүсэх гүйцэтгэлийн үүргийн хувьд гаднын талыг тусгайлан тодорхойлох шаардлагагүй боловч нөөцийг гадагш зарцуулах шаардлагыг түүнд тусган оруулсан эсэхийг тогтоохын тулд ийм үүргийг шинжлэх нь чухал ач холбогдолтой гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Нөөцийг ашиглах эрх олгохыг байгууллагаас шаардах боловч нөөцийн гадагш зарцуулалтыг өөртөө агуулаагүй үүрэг нь өр төлбөр үүсэхэд хүргэхгүй. Гэвч ирээдүйн нөөцийг гадагш зарцуулахыг байгууллагаас шаарддаг үүрэг нь өр төлбөр байж болох юм. Гүйцэтгэлийн үүрэг нь ямагт нөхцөлт үүрэг байдаг. Ийм үүрэг нь өр төлбөр үүсэхэд хүргэх эсэхийг тодорхойлох нь тухайн заавал биелүүлэх хэлцлийн нөхцлүүдээс хамаарах бөгөөд улс орон бүрд өөр байж болох юм. Гүйцэтгэлийн үүрэг нь өр төлбөр үүсэхэд хүргэх нөхцөл байдлыг стандартын түвшинд авч үзэх хэрэгтэй гэж УСНББОУСЗ дүгнэсэн.

*Өнгөрсөн үйл явдал*

ДҮ5.28. Өр төлбөрийн тодорхойлолт нь өнгөрсөн ажил гүйлгээ буюу бусад үйл явдал оршин байхыг шаардах хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ авч үзсэн. Өнгөрсөн үйл явдлыг тодорхойлох нь өр төлбөрийн чухал шинж чанар биш

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

бөгөөд иймээс өр төлбөрийн тодорхойлолтод өнгөрсөн үйл явдал гэдэг хэллэг оруулах шаардлагагүй гэсэн байр суурийг зарим хүмүүс баримталдаг. Ингэж тайлбарласан хүмүүс нь боломжит олон өнгөрсөн үйл явдал байж болох бөгөөд гол чухал өнгөрсөн үйл явдлын тогтоолт нь санамсаргүй тохиолдлын шинжтэй байх магадлалтай гэж үзсэн. Өнгөрсөн үйл явдлын олж тогтоолт нь тухайн тайлангийн өдрөөр өр төлбөр оршин байх эсэхийг тодорхойлох үндсэн хүчин зүйл биш гэсэн саналыг тэд илэрхийлсэн. Энэхүү байр суурь нь ДҮ5.15-ДҮ5.18-р параграфт авч хэлэлцсэн, хөрөнгийн тодорхойлолтод өнгөрсөн үйл явдлыг тусган оруулахын эсрэг байр суурийн толин тусгал болно.

ДҮ5.29. УСНББОУСЗ нь энэхүү үзэл бодлыг хүлээн зөвшөөрч байгаа боловч Зөвлөлдөх Баримт Бичиг болон Саналын Төсөлд хариулт ирүүлсэн олон хүмүүс нь өнгөрсөн үйл явдал бол өр төлбөрийн шинж чанар гэж үзсэн болохыг бас тэмдэглэсэн. Улсын секторын олон хөтөлбөр ба үйл ажиллагааны нарийн цогц байдал, түүнчлэн одоогийн үүрэг үүсэж болох боломжит олон агшин нь анхаарал татна гэсэн уг үзэл бодлыг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрдөг боловч өр төлбөр үүсэхэд хүргэх өнгөрсөн үйл явдлыг олж тогтоох нь улсын секторын өр төлбөрийг хэзээ хүлээн зөвшөөрөх хэрэгтэй эсэхийг тодорхойлоход чухал ач холбогдолтой гэж үзсэн.

*Зайлсхийх бодит боломжгүй буюу боломж бага байх*

ДҮ5.30. Одоогийн үүргийн тайлбар тодорхойлолтод оруулсан “зайлсхийх бодит боломжгүй буюу боломж багатай” гэсэн хэллэгийг янз бүрээр тайлбарлах боломжтой нээлттэй байгаад санаа зовж буйгаа Саналын Төсөлд хариулт ирүүлсэн зарим хүмүүс илэрхийлсэн. Буруу тайлбарлах боломжийг багасгахын тулд “боломж бага” гэсэн үгийг энэхүү хэллэгээс хасахыг тэд санал болгосон. УСНББОУСЗ нь энэ саналыг авч хэлэлцсэн. Одоогийн үүрэг оршин буй эсэхийг тодорхойлох үнэн бодит байдлын босго шалгуур байдлаар ийм өөрчлөлтийн үр дүнг тайлбарлаж болох юм гэдэгт УСНББОУСЗ нь санаа зовж байсан. Ийм босго шалгуур нь хэт өндөр гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Иймээс одоогийн үүрэг нь хуулиар хүлээсэн заавал биелүүлэх үүрэг, эсвэл байгууллага нь зайлсхийх бодит боломжгүй буюу боломж багатай, хуулиар хүлээгээгүй заавал биелүүлэх үүрэг байна гэдгийг УСНББОУСЗ баталгаажуулсан.

ДҮ5.31. Улсын секторын хүрээнд одоогийн үүрэг хэзээ үүсэх эсэхийг тодорхойлох нь төвөгтэй бөгөөд зарим үед санамсаргүй тохиолдлын байдлаар авч үзэж болох юм. Хууль буюу адилтгах арга хэрэгслээр хүчин төгөлдөр хэрэгжүүлэх боломжгүй үүргээс өр төлбөр үүсэх эсэхийг авч үзэх үед ялангуяа ийм тохиолдол үүсдэг. Нийгмийн халамж үзүүлэх хөтөлбөрийн хүрээнд одоогийн үүрэг үүсэх олон үе шатууд байдаг бөгөөд хэдийгээр хөтөлбөрүүд нь ижил төсөөтэй боловч улс орнуудын хооронд мэдэгдэхүйц ялгаатай, эсвэл нэг улс оронд мөн цаг хугацааны хувьд зөрүүтэй байж болно. Жишээлбэл; янз бүрийн насны бүлэг хүмүүс нь нийгмийн тусламжийн хөтөлбөрийн дагуу тэтгэмж авах магадлалын талаар өөр өөр хүлээлттэй байж болно. Ийм хүлээлтийг засгийн газар үгүйсгэж чадахгүй бөгөөд иймээс нөөцийг шилжүүлэх бодит боломжгүй буюу боломж багатай

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

гэж үнэлэх нь субъектив шинжтэй байж болох юм. Ийм субъектив байдал нь өр төлбөрийн тайлагналын тууштай байдлыг алдагдуулах ба ойлгомжтой байдалд мөн сөргөөр нөлөөлнө гэсэн санаа зовнил үүсэхэд хүргэдэг. Иймээс зарим хүмүүс нь өр төлбөрийн чухал шинж чанар бол хуулийн буюу бусад адилтгах арга хэрэгслээр тухайн тайлангийн өдөр хүчин төгөлдөр хэрэгжих боломжтой байх явдал юм гэсэн үзэл бодлыг илэрхийлсэн.

ДҮ5.32. Үүний эсрэг үзэл бодлоор бол засгийн газар нь үүрэгтээ зохицуулалт хийсэн бүртгэл хөтөлж, түүнийг өр төлбөр гэж хүлээн зөвшөөрөхгүй байх нь уг засгийн газрын цэвэр санхүүгийн байдлыг илүү илэрхийлэхэд хүргэх юм. Энэхүү үзэл бодлын дагуу, хэрэв засгийн газар нь тухайлбал, байгалийн гамшигт өртөгсдөд санхүүгийн дэмжлэг үзүүлэх талаар олон нийтэд зарлан мэдэгдсэн үүргийн хувьд иргэдэд үүсгэсэн хүлээлтийн тууштай бүртгэлийг хөтөлдөг бөгөөд ийм үүргээ өнгөрсөн хугацаанд биелүүлж байсан бол тэрхүү үүргийг өр төлбөр гэж хүлээн зөвшөөрөхгүй байх нь санхүүгийн тайлагналын зорилтуудтай нийцэхгүй, түүнчлэн үнэн зөв илэрхийлэх ба хамааралтай байх гэсэн чанарын шинжийг хангахгүй мэдээлэл бэлтгэхэд хүргэх юм.

ДҮ5.33. Хэдийгээр хуулиар хүчин төгөлдөр хэрэгжихгүй боловч байгууллага нь зайлсхийх бодит боломжгүй буюу боломж багатай заавал биелүүлэх үүргээс улсын секторт өр төлбөр үүсдэг гэж үзсэн хүмүүстэй УСНББОУСЗ нь үндсэндээ санал нэг байсан. УСНББОУСЗ нь ийм үүргийн хувьд “хуулиар хүлээгээгүй заавал биелүүлэх үүрэг” гэсэн нэр томъёог Онолын үзэл баримтлалд ашиглахаар шийдвэрлэсэн. Гэвч хуулиар хүчин төгөлдөр хэрэгжихгүй үүргээс өр төлбөр үүснэ гэдэгт эргэлзэж буй хүмүүсийн үзэл бодлыг УСНББОУСЗ нь хүндэтгэн үзсэн. Иймээс хуулиар хүлээгээгүй заавал биелүүлэх үүрэг нь өр төлбөр үүсэхэд хүргэхийн тулд түүнд агуулагдах шинжүүдийг энэ Бүлгийн 5.23-р параграфт тодорхойлсон.

ДҮ5.34. Хуулийн дагуу хүчин төгөлдөр хэрэгжихгүй үүрэг нь заавал биелүүлэх үүрэг болох, ингэснээр одоогийн үүрэг үүсэхэд хүргэх тийм нөхцөл байдлуудын бүлэглэсэн батламж мэдэгдэл нь тохиромжгүй гэдгийг улсын секторын хөтөлбөр ба үйл ажиллагааны шинж төрлийн олон янз байдал, дэлхийн улс орнуудын улс төрийн болон эдийн засгийн ялгаатай нөхцөл байдал илэрхийлдэг. Гэвч сонгуулийн амлалтаас одоогийн үүрэг үүсэх магадлал маш бага гэж УСНББОУСЗ үздэг. Яагаад гэвэл, сонгуулийн амлалт нь (а) тухайн байгууллага амлалтаа биелүүлнэ гэсэн хүчин төгөлдөр хүлээлтийг гаднын талуудад бараг төрүүлдэггүй, ба (б) байгууллага нь биелүүлэхээс өөр бодит боломжгүй тийм үүрэг бараг үүсгэдэггүй. Иймээс өр төлбөр нь сонгуулийн амлалтаас үүсэхгүй гэсэн урьдчилсан нөхцлийг Үзэл баримтлалд тусган оруулсан. Гэвч практикт дийлэнхи олонхийн засгийн газар нь цөөнхийн талтай харьцуулахад өөрийн зорьж буй хууль тогтоомжийг хүчин төгөлдөр болгон батлуулах илүү сайн байр суурьтай бөгөөд ийм нөхцөл байдалд засгийн газрын мэдэгдэл нь өр төлбөр үүсэхэд хүргэдэг зарим тохиолдол байж болох юм. Ийм нөхцөл байдалд хуулиар хүлээгээгүй заавал биелүүлэх үүрэг нь өр төлбөр үүсэхэд хүргэх эсэхийг үнэлэхэд тухайн үүргийг барагдуулах санхүүжилтийн бэлэн боломжтой

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

байдал нь шалгуур үзүүлэлт болох юм. Үүнийг 5.25-р параграфт авч хэлэлцсэн.

*Үүргээс зайлсхийх онцгой бүрэн эрх*

ДҮ5.35. Онцгой бүрэн эрх нь хуулийн зүйл заалтыг тогтоох, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох засгийн газрын гол шинж чанар юм. Онцгой бүрэн эрх нь арилжааны ба арилжааны бус ажил гүйлгээний аль алинаас үүсэх үүргээс татгалзах боломжийг засгийн газарт олгодог. Глобал орчинд ийм бүрэн эрхийг практик ач холбогдлоор хязгаарлаж болох боловч засгийн газар нь санхүүгийн үүргээ үл биелүүлэх маш олон жишээ өнгөрсөн зуунд гарч байсан. Өр төлбөрийн тодорхойлолтод онцгой бүрэн эрхийн үзүүлэх үр нөлөөг УСНББОУСЗ харгалзан үзсэн. Онцгой бүрэн эрх нь ийм үүргээс чөлөөлөгдөх боломжийг засгийн газарт олгоно гэсэн үндэслэлээр өр төлбөрийн тодорхойлолтыг бусад байдлаар хангах үүргийг хүлээн зөвшөөрөхгүй байх нь санхүүгийн тайлагналын зорилтуудтай нийцэхгүй бөгөөд ялангуяа, хамааралтай байх ба үнэн зөв илэрхийлэх гэсэн чанарын шинжүүдтэй зөрчилдөж болох юм гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Зөвлөлдөх Баримт Бичиг болон Саналын Төсөлд хариулт ирүүлсэн олон хүмүүс нь энэ байр суурийг дэмжсэн. Иймээс өр төлбөрийн оршин байдлын тодорхойлолт нь тухайн тайлангийн өдрөөрх хууль эрх зүйн байр суурийг харгалзсан байвал зохино гэж УСНББОУСЗ дүгнэсэн.

*Баталгаа*

ДҮ5.36. Баталгааны нягтлан бодох бүртгэлийн горим нь олон улс орны хувьд улсын секторын байгууллагуудын төсвийн хяналтын гол бүрэлдэхүүн хэсэг байдаг. Баталгаа нь ирээдүйн боломжит өр төлбөр, үүн дотроо төлөвлөсөн буюу хэрэгжээгүй байгаа худалдан авалтын захиалга ба гэрээний хувьд, эсвэл мөнгө сангийн ирээдүйн шилжүүлгийн нөхцөл хангагдаагүй тохиолдолд тухайн засгийн газрын болон улсын секторын бусад байгууллагын үүрэг хариуцлагыг биелүүлэх төсвийн мөнгө сан бэлэн, хүрэлцээтэй гэдгийг ханган магадлах санаа зорилготой юм. Өр төлбөрийн тодорхойлолт ба хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангасан баталгааг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрдөг, үүнээс бусад тохиолдолд тэдгээрийн талаархи мэдээллийг санхүүгийн тайлангийн тодруулгад, эсвэл НЗСТ-д агуулагдсан бусад тайланд тусган хүргэн танилцуулж болох юм. Санхүүгийн тайланд хамаарахгүй, нийтлэг зорилготой санхүүгийн тайлагналын илүү дэлгэрэнгүй талбаруудын хувьд элементүүдийг ирээдүйд авч үзэх үедээ баталгааны нягтлан бодох бүртгэлийг харгалзан тусгаж болох юм гэж УСНББОУСЗ дүгнэсэн.

**Цэвэр санхүүгийн байдал, бусад нөөц ба бусад үүрэг**

ДҮ5.37. Санхүүгийн тайланд тайлагнах санхүүгийн үр дүнгийн загварын талаархи УСНББОУСЗ-ийн арга хандлагыг, ялангуяа хойшлогдсон орлогын гүйлгээ болон хойшлогдсон зарлагын гүйлгээний аргыг Дүгнэлтийн Үндэслэлийн энэхүү хэсэгт авч үзнэ.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

*Зөвлөлдөх Баримт Бичиг, “Элементүүд ба Санхүүгийн Тайлан дахь Хүлээн Зөвшөөрөлт”*

ДҮ5.38. Санхүүгийн үр дүнгийн эсрэг тэсрэг хоёр хандлагыг Зөвлөлдөх Баримт Бичигт авч хэлэлцсэн:

- Байгууллагын нөөц ба үүргийн тухайн тайлант үеийн турш дахь бүх өөрчлөлтийн цэвэр үр дүн байдлаар санхүүгийн үр дүнг хэмждэг хандлага. Үүнийг хөрөнгө, өр төлбөрт чиглэсэн хандлага гэж нэрлэдэг;
- Тухайн тайлант үеийн үйл ажиллагаатай илүү нягт холбоотой орлогын болон зардлын гүйлгээний үр дүн байдлаар санхүүгийн үр дүнг хэмждэг хандлага. Үүнийг орлого, зардалд чиглэсэн хандлага гэж нэрлэдэг.

ДҮ5.39. Энэхүү ялгаатай хоёр хандлага нь санхүүгийн үр дүн болон санхүүгийн байдалтай холбоотой элементүүдийг өөр өөр байдлаар тодорхойлоход хүргэж болох юм гэдгийг Зөвлөлдөх Баримт Бичигт тэмдэглэсэн. Орлого, зардалд чиглэсэн хандлага нь завсрын үе хоорондын тэнцвэрийн тухай ойлголттой нягт холбоотой байдаг. Завсрын үе хоорондын тэнцвэр нь тухайн тайлант үеийн хөтөлбөрийн болон үйлчилгээ үзүүлэх өртөг зардлыг одоогийн татвар төлөгчид ба одоогийн нөөцөөр хангагчид хариуцах хэмжээг илэрхийлдэг. Хөрөнгө, өр төлбөрт чиглэсэн хандлага нь ирээдүйд үйлчилгээ үзүүлэх бэлэн боломжтой байгаа нөөц болон тайлант үеийн үйл ажиллагааны үр дүнд тэдгээр нөөцийн нэхэмжлэлд гарсан өөрчлөлтийн талаархи ойлголттой нягт холбоотой байдаг.

ДҮ5.40. Бусад боломжит элементүүдийг Зөвлөлдөх Баримт Бичгийн дараагийн хэсэгт авч хэлэлцсэн бөгөөд хэрэв УСНББОУСЗ нь орлого, зардалд чиглэсэн хандлагыг баталсан бол хойшлогдсон гүйлгээг авч үзэх шаардлагатай гэдгийг цохон тэмдэглэсэн. Энэхүү хандлагын дагуу, хойшлогдсон гүйлгээ нь орлого, зардлын санал болгосон тодорхойлолтыг хангахгүй боловч тухайн тайлант үеийн санхүүгийн үр дүнд ямар нэг байдлаар нөлөөлнө гэж үзсэн зүйлс юм. Ийм гүйлгээг авч үзэх гурван сонголтыг Зөвлөлдөх Баримт Бичигт тодорхойлсон:

- Хойшлогдсон орлогын гүйлгээ болон хойшлогдсон зарлагын гүйлгээг санхүүгийн байдлын тайлангийн элементүүд гэж тодорхойлох;
- Хойшлогдсон зүйлсийг тусган оруулахын тулд хөрөнгө, өр төлбөрийн тодорхойлолтыг өргөжүүлэх;
- Хойшлогдсон гүйлгээг цэвэр хөрөнгө/цэвэр өр төлбөрийн дэд ангилал (дараагийн тайлант үед үүнийг үлдэх дүн гэж нэрлэдэг) гэж тодорхойлох.

ДҮ5.41. Эдгээр талбарын талаар санал зөвлөмж авахын тулд тодорхой хоёр асуудлыг Зөвлөлдөх Баримт Бичигт тусгасан. Нэгдүгээрт, сонгогчид нь хөрөнгө, өр төлбөрт чиглэсэн хандлагыг, эсвэл орлого, зардалд чиглэсэн хандлагыг илүүд үзэж буй эсэхээ илэрхийлэх ба үүний шалтгаан



УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

үндэслэлээ тайлбарлахыг тэднээс хүссэн. Хоёрдугаарт, хойшлогдсон орлогын гүйлгээ болон хойшлогдсон зарлагын гүйлгээг санхүүгийн байдлын тайланд тодорхойлох шаардлагатай эсэхийг асуусан. Хэрэв санхүүгийн байдлын тайланд тодорхойлохыг дэмжиж байвал ДҮ5.40-р параграфт заасан гурван хандлагын алийг дэмжиж байгаа гэдгээ илэрхийлэхийг тэднээс хүсдэг.

ДҮ5.42. Санал зөвлөмж авах эдгээр тусгай асуудлуудын хариулт нь дүгнэлтийн шинжтэй бус байсан. Байр сууриа илэрхийлсэн ихэнх хариулт ирүүлсэн хүмүүс нь хөрөнгө, өр төлбөрт чиглэсэн хандлагыг дэмжсэн. Гэвч хөрөнгө, өр төлбөрт чиглэсэн хандлагыг дэмждэг, хариулт ирүүлсэн олон хүмүүс нь санхүүгийн байдлын тайланд хойшлогдсон зүйлсийг тодорхойлохыг дэмжиж байгаагаар мөн илэрхийлсэн. УСНББОУСЗ нь эдгээр байр суурийг Саналын Төслийн үе шатанд харгалзан үзсэн.

*Саналын Төсөл, Элементүүд ба Санхүүгийн Тайлан дахь Хүлээн Зөвшөөрөлт*

ДҮ5.43. Тухайн тайлант үетэй холбоотой гүйлгээг тусгайлан заасан ирээдүйн тайлант үеүдтэй холбоотой гүйлгээнээс ялган зааглах боломжтой байх нь чухал гэсэн байр суурийг Саналын Төсөлд илэрхийлсэн. Иймээс Саналын Төсөлд хойшлогдсон орлогын гүйлгээ болон хойшлогдсон зарлагын гүйлгээний дараах тодорхойлолтыг санал болгосон:

- *Хойшлогдсон орлогын гүйлгээ нь арилжааны бус ажил гүйлгээнээс үүсэж, цэвэр хөрөнгийг нэмэгдүүлэх бөгөөд тусгайлан заасан ирээдүйн тайлант үед ашиглагдах байдлаар тухайн байгууллагад бий болсон үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөжийн орлогын гүйлгээ юм;*
- *Хойшлогдсон зарлагын гүйлгээ нь арилжааны бус ажил гүйлгээнээс үүсэж, цэвэр хөрөнгийг бууруулах бөгөөд тусгайлан заасан ирээдүйн тайлант үед ашиглагдах байдлаар өөр байгууллага буюу талд олгосон үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөжийн зарлагын гүйлгээ юм.*

ДҮ5.44. Эдгээр тодорхойлолтын хоёр гол шинж нь:

- Санал болгож буй элементүүдийг арилжааны бус ажил гүйлгээгээр хязгаарласан;
- Тухайн гүйлгээ нь тусгайлан заасан ирээдүйн тайлант үетэй холбоотой байна.

ДҮ5.45. Эдгээр шинж чанаруудыг тусган оруулсан УСНББОУСЗ-ийн учир шалтгаан нь хойшлогдсон орлогын гүйлгээ болон хойшлогдсон зарлагын гүйлгээг жигдрүүлэх арга хэрэгсэл болгон нийтлэг ашиглах боломжийг багасгах, түүнчлэн хойшлогдсон орлогын гүйлгээ ба хойшлогдсон зарлагын гүйлгээг тодорхойгүй шалтгаанаар санхүүгийн байдлын тайланд толилуулаагүй гэдгийг ханган магадлах, эрсдлээс сэргийлэх арга хэмжээ болгох явдал юм. Саналын Төсөлд боломжит хоёр үзэл бодлыг тусган илэрхийлсэн. Эхний үзэл бодлын дагуу, хойшлогдсон орлогын гүйлгээ болон хойшлогдсон

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

зарлагын гүйлгээний нэгдсэн үр нөлөөгөөр цэвэр санхүүгийн байдлын утга тодорхой бус болно гэж үздэг. Хоёр дахь үзэл бодол нь энэхүү үзэл бодлыг хүлээн зөвшөөрдөггүй, түүнчлэн хойшлогдсон орлогын гүйлгээ ба хойшлогдсон зарлагын гүйлгээг тодорхойлж, тусдаа элемент байдлаар хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэж үздэг бөгөөд эдгээр гүйлгээ нь орлого, зардлын тодорхойлолтыг хангана гэсэн байр суурийг илэрхийлсэн.

ДҮ5.46. Хариулт өгсөн олон хүмүүс нь хойшлогдсон орлогын гүйлгээ болон хойшлогдсон зарлагын гүйлгээг элемент гэж тодорхойлохтой санал нийлээгүй. Зарим хүмүүс нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Онолын Үзэл Баримтлал болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарттай нийцүүлэх ач холбогдлын талаархи саналаа илүү ерөнхий байдлаар илэрхийлсэн. Уг санал болгож буй хандлага нь эдийн засгийн бодит байдлыг тусгадаггүй бөгөөд орлого, зардалд чиглэсэн хандлагын дагуу орлого, зардлыг хойшлуулах бодитой суурийг тодорхойлоход төвөгтэй гэж хариулт өгсөн олон хүмүүс үзэж байсан. Гэвч тухайн тодорхой тайлант үеүдтэй холбоотой гүйлгээний талаархи мэдээлэл нь мэдээллийн үнэ цэнэтэй гэсэн байр суурийг хариулт өгсөн олон хүмүүс илэрхийлсэн.

ДҮ5.47. Хойшлогдсон орлогын гүйлгээ ба хойшлогдсон зарлагын гүйлгээг элемент гэж тодорхойлохыг дэмждэг, түүнчлэн эдгээр санал болгосон элементийг дэмждэггүй хүмүүсийн аль аль нь уг тодорхойлолтыг арилжааны бус ажил гүйлгээгээр хязгаарлах учир шалтгаан нь онолын хувьд үндэслэл муутай гэж үзсэн. Тусгайлан заасан тайлант хугацаагаар хязгаарлах нь тодорхой тайлант үеийг тогтоосон эсэхээс хамааран ижил төсөөтэй ажил гүйлгээнүүдийн хувьд нягтлан бодох бүртгэлийн өөр өөр арга хэрэглэхэд хүргэх учраас хариулт өгсөн хүмүүс нь мөн ийм хязгаарлалттай санал нийлээгүй. Жишээлбэл; өөрийн ерөнхий үйл ажиллагааг санхүүжүүлэхийн тулд тухайн байгууллагын таван жилийн хугацаатай авах, нөхцөл заагаагүй буцалтгүй тусламж нь хойшлогдсон орлогын гүйлгээний тодорхойлолтыг хангана, харин ирээдүйн тодорхой хугацаа заагаагүй адилтгах буцалтгүй тусламж нь орлогын тодорхойлолтыг хангахгүй болоход хүрэх юм.

*Элементийн талаархи бүлгийн дүгнэлт*

ДҮ5.48. Саналын Төсөлд тусгасан, хойшлогдсон гүйлгээний талаархи саналд өгсөн цөөн хязгаарлагдмал дэмжлэг ба тодорхой тайлант үеүдтэй холбоотой гүйлгээний хувьд хэрэглэгчдийн мэдээллийн төсөөлсөн хэрэгцээний хоорондох тэнцвэрийг хангах шаардлагатай гэж УСНББОУСЗ үзсэн.

ДҮ5.49. Иймээс УСНББОУСЗ нь албаны үйл ажиллагааны явцад олж авсан мэдээ болон хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээний талаархи өөрийн ойлголтыг харгалзан 5 хувилбарыг (доорх А-гаас Д) авч үзсэн:

А. Хойшлогдсон орлогын гүйлгээ болон хойшлогдсон зарлагын гүйлгээг зарчимд илүүтэй суурилсан байдлаар элемент гэж тодорхойлох ба тэдгээр элементүүдийг аль санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөхийг

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

тусгайлан заахгүй байх. Ингэснээр элементүүдийн толилуулгыг Онолын үзэл баримтлалд урьдчилан тодорхойлохгүй юм;

- Б. Хөрөнгө, өр төлбөрийн тодорхойлолтод үндэслэн орлого ба зардлын тодорхойлолтыг гаргах;
- В. Хөрөнгө, өр төлбөрийн тодорхойлолтыг өргөжүүлэх;
- Г. Санхүүгийн тайлагналын зорилтуудыг хангахын тулд санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөх шаардлагатай байж болох аливаа элементийн тодорхойлолтыг хангахгүй тийм эдийн засгийн зарим юмс үзэгдэл байдгийг хүлээн зөвшөөрөх;
- Д. Үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөжөөр хангах боловч Онолын үзэл баримтлалд тодорхойлсон хөрөнгө, өр төлбөрт нөлөөлөхгүй орлогын болон зарлагын гүйлгээг тайлагнах, мөн орлого, зардалд нөлөөлөхгүй орлогын болон зарлагын гүйлгээг тайлагнах.

ДҮ5.50. Хариулт өгсөн хүмүүсийн Саналын Төсөлд илэрхийлсэн эсэргүүцлийг харгалзан үзсэнээр, УСНББОУСЗ нь Хувилбар А-гийн дагуу хойшлогдсон орлогын гүйлгээ ба хойшлогдсон зарлагын гүйлгээг элемент гэж хүлээн зөвшөөрөх нь зохисгүй гэж үзсэн. Иймээс УСНББОУСЗ нь Хувилбар А-гаас татгалзсан.

ДҮ5.51. УСНББОУСЗ нь Хувилбар Б-гийн хоёр сонголтыг харгалзан үзсэн. Эхний сонголтоор, хойшлогдсон гүйлгээг шууд ашиг, алдагдалд тусгана, харин хоёр дахь сонголтын дагуу, хойшлогдсон гүйлгээг эхлээд үлдэх дүнгээр илэрхийлэх ба цаг хугацааны нөхцөл биелэгдсэн тайлант үед ашиг, алдагдалд дараа нь дахин тайлагнана.

ДҮ5.52. Хувилбар Б-гийн эхний сонголтын дагуу, хойшлогдсон гүйлгээг ашиг, алдагдалд шууд тусгах нь байгууллагын тогтвортой гүйцэтгэл, үр дүнг үнэн зөв төлөөлөн илэрхийлэх мэдээллээр хангаж чадахгүй, иймээс санхүүгийн тайлагналын зорилтуудад нийцэхгүй гэж УСНББОУСЗ үзсэн. Хувилбар Б-гийн хоёр дахь сонголт нь дахин тайлагналд үндэслэдэг бөгөөд УСНББОУСЗ-ийн зарим гишүүдийн үзэж байгаагаар “бусад дэлгэрэнгүй орлого” гэсэн ойлголтыг Онолын үзэл баримтлалд шууд бусаар оруулахад хүргэнэ. УСНББОУСЗ нь ийм хөгжүүлэлтийн хувьд хатуу байр суурьтай байдаг. Энэ шалтгаанаар УСНББОУСЗ нь Хувилбар Б-гээс татгалзсан.

ДҮ5.53. Хувилбар В нь хөрөнгө, өр төлбөрийн тодорхойлолтод өөрчлөлт оруулахыг шаардах бөгөөд ингэснээр дараах үр дагавартай болно гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн:

- Хөрөнгийн тодорхойлолтод тухайн байгууллагын хяналтанд байдаггүй нөөцийг тусган оруулах;
- Өр төлбөрийн тодорхойлолтод одоогийн үүрэг биш тийм үүргийг тусган оруулах.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Ийм өөрчлөлтүүд нь байгууллага нөөцийн хувьд эрхийг хянадаг байх гэсэн хөрөнгийн чухал шинж чанарыг, түүнчлэн байгууллага нөөцийн гадагш зарцуулалтын хувьд одоогийн үүрэгтэй байх гэсэн өр төлбөрийн чухал шинж чанарыг алдагдуулна гэж УСНББОУСЗ дүгнэсэн. УСНББОУСЗ-ийн үзэж байгаагаар, энэ нь хөрөнгө, өр төлбөрийн хялбар ойлгомжтой байдлыг алдагдуулна. Ийм хувилбарыг батлах нь хөрөнгө, өр төлбөрийн дэлхий нийтээр ойлгодог тодорхойлолтоос гажихад бас хүргэх юм. Энэ шалтгаанаар УСНББОУСЗ нь Хувилбар В-гээс татгалзсан.

ДҮ5.54. Хувилбар Д нь бусад дөрвөн хувилбарын бүрэлдэхүүн хэсгүүдийг агуулсан холимог хандлага юм. Энэ нь үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөжөөр хангах боловч хөрөнгө, өр төлбөрийн тодорхойлолтод нөлөөлөхгүй орлогын болон зарлагын гүйлгээг тайлагнах, мөн Онолын үзэл баримтлалд тодорхойлсон орлого, зардалд нөлөөлөхгүй орлогын болон зарлагын гүйлгээг тайлагнахыг зөвшөөрдөг. Энэхүү хандлагын гол санаа нь санхүүгийн үр дүнгийн талаархи онолын үзэл баримтлалыг цаашид боловсруулах шаардлагатай гэдгийг илэрхийлж байна.

ДҮ5.55. Хувилбар Г нь хойшлогдсон гүйлгээгээр хязгаарлагдах албагүй боловч эдийн засгийн илүү өргөн хүрээтэй юмс үзэгдлийг агуулж болох учраас Хувилбар Д-гээс өргөн хүрээтэй байдаг. Жишээлбэл; гүйцэтгэлийн үүргийг агуулдаг боловч нөөцийн гадагш зарцуулалтыг шаардах эсэх нь тодорхойгүй, одоогийн үүрэг биш тийм үүргийг агуулах. Онолын үзэл баримтлалд тодорхойлсон зургаан элемент нь хэрэглэгчдийн хэрэгцээг хангахад шаардлагатай бүх мэдээллийг санхүүгийн тайланд тусган бүрдүүлээгүй тийм нөхцөл байдал байж болох юм гэдгийг Хувилбар Г-д хүлээн зөвшөөрдөг. Тэдгээр бусад зүйлсийг хүлээн зөвшөөрч болно гэдэг нь эндээс тодорхой байна гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Хувилбар Г нь Хувилбар А-гаас ялгаатай нь, нэмэлт элементүүдийг тодорхойлдоггүй, харин Хувилбар В-гээс ялгаатай нь, хөрөнгө ба өр төлбөрийн нийтээр ойлгодог тодорхойлолтыг өөрчлөхөд хүргэхгүй.

ДҮ5.56. Хувилбар Г нь хамгийн ил тод, ойлгомжтой арга хандлагыг бүрдүүлнэ гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Эдгээр эдийн засгийн юмс үзэгдлийг Онолын үзэл баримтлалд тайлбарлан тодорхойлохын тулд “бусад үүрэг”, “бусад нөөц” гэсэн нэр томъёог ашигладаг. Бусад үүрэг ба бусад нөөцийг хүлээн зөвшөөрөх нөхцөл байдлыг стандартын түвшинд тодорхойлох бөгөөд тухайн хамаарах стандартуудын Дүгнэлтийн Үндэслэлд тайлбарлах учраас Хувилбар Г нь УСНББОУСЗ-ийн хариуцлагыг бас нэмэгдүүлдэг.

#### *Санхүүгийн тайлан*

ДҮ5.57. Цэвэр санхүүгийн байдал нь тухайн тайлангийн өдрөөр санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрсөн уг байгууллагын цэвэр хөрөнгө (хөрөнгөөс өр төлбөрийг хассан дүн), түүнчлэн бусад нөөц ба бусад үүргийн нэгдсэн дүн юм. Элементийн тодорхойлолтыг хангаж байгаагаас бусад, нөөц болон үүргийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн тохиолдолд цэвэр хөрөнгө ба цэвэр санхүүгийн байдал гэж тайлагнасан дүнгүүд хоорондоо өөр байна. Ийм тохиолдолд холбогдох УСНББОУС-ын

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

дагуу санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн, бусад нөөц ба бусад үүргийн шинж төрлийг лавлагаа болгон харгалзсанаар цэвэр санхүүгийн байдлын тайлбар утгыг тодорхойлно.

ДҮ5.58. УСНББОУСЗ нь “цэвэр хөрөнгө” ба “цэвэр санхүүгийн байдал” гэсэн нэр томъёоны аль алиныг Онолын үзэл баримтлалд ашиглах хэрэгтэй эсэхийг харгалзан үзсэн. Цэвэр хөрөнгө нь нийтээр ойлгодог нэр томъёо гэсэн байр суурийг УСНББОУСЗ илэрхийлсэн. Гэвч УСНББОУСЗ нь хоёр нэр томъёоны аль алиныг ашиглах нь төөрөгдөлд хүргэнэ гэж үзсэн ба иймээс байгууллагын үлдэх дүнг илэрхийлэхийн тулд “цэвэр санхүүгийн байдал” гэсэн нэр томъёог ашиглахаар шийдвэрлэсэн.

## Орлого ба зардал

*Орлогын тодорхойлолтод заасан, “Цэвэр санхүүгийн байдал”-ын нийт эсвэл цэвэр өсөлт*

ДҮ5.59. Цэвэр санхүүгийн байдлын өсөлт нь “нийт” эсвэл “цэвэр” дүн эсэхийг орлогын тодорхойлолтод тусгайлан заах хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ авч үзсэн. Нийт дүнгийн хандлага нь данснаас хасалтын орлого ба дансны үнийн хоорондох зөрүүг биш, харин данснаас хасалтын орлогын нийт дүнгээр орлого гэж хүлээн зөвшөөрөхийг шаардах учраас үндсэн хөрөнгийн данснаас хасалт гэх мэт талбарын хувьд уг хандлага тохиромжтой биш байж болно гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Харин эсрэгээр, цэвэр дүнгийн хандлага нь тухайлбал, бараа материалын борлуулалт гэх мэт зарим тохиолдолд үүнтэй адилаар тохиромжгүй байж болох юм. Аль арга хандлага нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг илүү сайн хангахаас хамааран тэрхүү орлогоор илэрхийлэгдэж буй цэвэр санхүүгийн байдлын өсөлтийг нийт дүнгээр эсвэл цэвэр дүнгээр тодорхойлох эсэхийг стандартын түвшинд тогтоох хэрэгтэй гэж УСНББОУСЗ дүгнэсэн.

*Үйл ажиллагааны хэвийн үйл явцад хамааралгүй ажиллагаанаас Ердийн үйл ажиллагааг ялган зааглах*

ДҮ5.60. Стандарт тогтоогч зарим байгууллага нь тухайлбал, ердийн үйл ажиллагаатай холбоотой ажил гүйлгээ ба үйл явдлаас үүссэн, орлогын болон зарлагын гүйлгээг үйл ажиллагааны хэвийн үйл явцад хамааралгүй ажиллагаанд хамаарах орлогын болон зарлагын гүйлгээнээс ялган зааглахын тулд элементүүдийн талаархи өөрсдийн тодорхойлолтыг бүтэцчлэн зохион байгуулдаг. Энэ хандлага нь жишээлбэл; орлого, зардлыг тухайн байгууллагын “гол буюу үндсэн тасралтгүй үйл ажиллагаа”-тай холбоотой элемент гэж тодорхойлох, харин олз, гарзыг түүний цэвэр хөрөнгийн өсөлт эсвэл бууралтад хүргэх бусад бүх ажил гүйлгээ, үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой элемент гэж тодорхойлох явдал юм.<sup>7</sup>

<sup>7</sup> Жишээлбэл; Санхүүгийн Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын Зөвлөлийн Санхүүгийн Нягтлан Бодох Бүртгэлийн Ухагдахууны Тунхаглал №6, “Санхүүгийн Тайлангийн Элементүүд”-ийг үзнэ үү.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТой  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

ДҮ5.61. Ердийн үйл ажиллагаатай холбоотой ажил гүйлгээ ба үйл явдлыг үйл ажиллагааны хэвийн үйл явцад хамааралгүй ажил гүйлгээ, үйл явдлаас ялган зааглах нь санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ач холбогдолтой мэдээллээр хангаж болох юм гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрдөг. Иймээс үйл ажиллагааны хэвийн үйл явцад хамааралгүй ажил гүйлгээ ба үйл явдлаас үүссэн орлогын болон зарлагын гүйлгээг тусгахын тулд “олз ба гарз” гэсэн нэр томъёог ашиглах нь ач холбогдолтой байж болно. Гэвч онолын хувьд, олз ба гарз нь орлого, зардлын бусад хэлбэрээс ялгаагүй, яагаад гэвэл эдгээрийн аль аль нь хөрөнгө, өр төлбөрийн цэвэр өсөлт эсвэл бууралтыг агуулдаг гэсэн байр суурийг УСНББОУСЗ илэрхийлсэн. Зөвлөлдөх Баримт Бичиг болон Саналын Төсөлд хариулт өгсөн олон хүмүүс нь энэ байр суурьтай санал нэг байсан гэдгийг УСНББОУСЗ бас тэмдэглэсэн. Иймээс УСНББОУСЗ нь олз, гарзыг тусдаа элемент байдлаар тодорхойлохгүй байхаар шийдвэрлэсэн.

*Улсын сектор дахь өмчлөлийн хувь оролцоо*

ДҮ5.62. ДҮ5.66-ДҮ5.70-р параграфт илүү дэлгэрэнгүй тайлбарласанчлан, улсын секторт өмчлөлийн хувь оролцоо оршин байх эсэх, хэрэв байгаа бол ямар нөхцөлд оршин байх, түүнчлэн өмчлөлийн хувь оролцоотой холбоотой ажил гүйлгээг орлого, зардлын тодорхойлолтоос хасах хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ нь авч үзсэн. Эзэд болохын хувьд тэдний бүрэн эрхийн хүрээнд эзэдтэй хийсэн ажил гүйлгээ нь нөөцийн бусад орлогын болон зарлагын гүйлгээнээс мөн чанарын хувьд өөр учраас эзэдтэй холбоотой гүйлгээг орлого, зардлаас ялган зааглах хэрэгтэй гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Иймээс өмчлөлийн хувь оролцоо ба өмчлөлийн хуваарилалтыг тусдаа элемент гэж тодорхойлдог бөгөөд орлого, зардлын тодорхойлолтод оруулдаггүй.

*Тайлант үеийн ашиг, алдагдал*

ДҮ5.63. Орлого ба зардлын хоорондох зөрүүг тухайн байгууллагын тайлант үеийн ашиг, алдагдал гэж энэ Бүлэгт заасан. УСНББОУСЗ нь ашиг, алдагдлыг тайлбарлах нэмэлт заавар удирдамж тусган оруулах хэрэгтэй эсэхийг авч үзсэн. Улсын секторын байгууллагууд нь үйл ажиллагааны болон санхүүжилтийн загвартай байдаг гэсэн үзэл бодлыг УСНББОУСЗ авч хэлэлцсэн. Энэхүү үзэл бодлын дагуу, ашиг нь тухайн байгууллагын дараах чадварыг илэрхийлэх үзүүлэлтээр хангадаг. Үүнд:

- Нөөцөөр хангагчдаас авах нөөцийн хэрэгцээ шаардлагыг багасгах;
- Үйлчилгээ хүлээн авагчдад үзүүлэх үйлчилгээний тоо хэмжээ ба/буюу чанарыг нэмэгдүүлэх;
- Өрийг бууруулах (байгууллага нь өрийн санхүүжилт авах бүрэн эрхтэй тохиолдолд);
- Эдгээр хүчин зүйлсийн хослол.

ДҮ5.64. Харин эсрэгээр, алдагдал нь дараах үзүүлэлтийг илэрхийлдэг:

- Нөөцөөр хангагчдаас авах нөөцийн хэрэгцээг нэмэгдүүлэх шаардлага;
- Үйлчилгээ хүлээн авагчдад үзүүлэх үйлчилгээний тоо хэмжээ ба/буюу чанарыг бууруулах;
- Өрийг нэмэгдүүлэх (байгууллага нь өрийн санхүүжилт авах бүрэн эрхтэй тохиолдолд);
- Эдгээр хүчин зүйлсийн хослол.

ДҮ5.65. Улсын сектор дахь ашиг, алдагдлын утга агуулгыг илүү тодорхой, ойлгомжтой болгох шаардлагатай, иймээс дээрх арга хандлагын төлөв байдлуудыг ирээдүйд улам боловсронгуй хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Гэвч үйл ажиллагааны болон санхүүжилтийн загвар эсвэл бизнесийн загвар гэсэн ойлголт ухагдахуун нь улсын секторт сайн хөгжөөгүй бөгөөд улсын секторын бүх байгууллагад тохиромжтой үйл ажиллагааны болон санхүүжилтийн загварыг боловсруулахад төвөгтэй гэж УСНББОУСЗ үзэж байна. Иймээс УСНББОУСЗ нь ашиг, алдагдлын тайлбарын талаархи заавар удирдамжийг Онолын үзэл баримтлалд тусган оруулахгүй байхаар шийдвэрлэсэн.

### **Өмчлөлийн хувь оролцоо ба өмчлөлийн хуваарилалт**

ДҮ5.66. Цэвэр санхүүгийн байдал нь үлдэх дүн, үлдэх хувь оролцоо эсвэл өмчлөлийн хувь оролцоо эсэхийг УСНББОУСЗ авч үзсэн. Байгууллагын урт хугацааны үр ашигт байдал, ирээдүйд үйлчилгээ үзүүлэх түүний чадвар ба нөөцөд дахин өөрчлөн чиглүүлэлт, бүтцийн өөрчлөлт буюу бусад адилтгах байдлаар оролцож болох нөөцөөр хангагчид болон үйлчилгээ хүлээн авагчдын хувь оролцоо нь өмчлөлийн хувь оролцоотой ижил төсөөтэй гэсэн байр суурийг УСНББОУСЗ илэрхийлсэн. Цэвэр хөрөнгө дэх гуравдагч талын хувь оролцоог илэрхийлэхийн тулд зарим улс оронд “үлдэх хувь оролцоо” болон “өмчлөлийн хувь оролцоо” гэсэн нэр томъёог ашигладаг болохыг УСНББОУСЗ мөн хүлээн зөвшөөрсөн. Үйлчилгээ хүлээн авагчид ба нөөцөөр хангагчид нь тухайн байгууллагын өөрийгөө санхүүжүүлэх болон ирээдүйн үйл ажиллагааны нөөцийг бүрдүүлэх чадвар боломжид хувь оролцоотой гэдгийг “үлдэх хувь оролцоо” нэр томъёо илэрхийлдэг. “Өмчлөлийн хувь оролцоо” нэр томъёо нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж дэх өмчлөлийн хувь оролцоотой ижил утгатай бөгөөд нөгөө талаас, энэ нь улсын секторын байгууллагын нөөцийг иргэд өмчилдөг ба тэдгээр нөөцийг ашигласны төлөө засгийн газар нь иргэдийн өмнө хариуцлага хүлээнэ гэдгийг илэрхийлдэг. Энэ нь засгийн газрын ардчилсан хариуцлагыг онцлон харуулна гэж уг хандлагын зарим дэмжигчид үздэг.

ДҮ5.67. Улсын секторын байгууллагад тэдгээр үйлчилгээ хүлээн авагчид болон нөөцөөр хангагчид санхүүгийн хувь оролцоотой болохыг “үлдэх хувь оролцоо” нэр томъёогоор бас илэрхийлж болно гэж УСНББОУСЗ үздэг. Үүнтэй адилаар, “өмчлөлийн хувь оролцоо” нэр томъёо нь улсын секторын байгууллагаас олгох хуваарилалт, түүнчлэн тухайн байгууллага татан

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

буугдах тохиолдолд нөөцийн хуваарилалтаас иргэд хүртэх эрхтэй гэдгийг илэрхийлж болох юм. Иймээс “үлдэх хувь оролцоо” ба “өмчлөлийн хувь оролцоо” гэсэн нэр томъёог буруугаар ойлгох буюу буруугаар тайлбарлаж болох юм гэж УСНББОУСЗ үзсэн бөгөөд цэвэр санхүүгийн байдал бол үлдэх дүн, үүнийг тодорхойлох хэрэггүй гэж дүгнэсэн.

ДҮ5.68. Харин зарим тохиолдолд цэвэр санхүүгийн байдлын тодорхой хэсэг нь өмчлөлийн хувь оролцоо байж болно гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрдөг. Албан ёсны өмчийн бүтэцтэй байгууллага нь ийм тохиолдлыг батлан харуулж болох юм. Гэвч арилжааны байгууллага байдлаар үйл ажиллагааг борлуулах зорилгоор албан ёсны өмчийн бүтэцгүй байгууллагыг үүсгэн байгуулах, эсвэл хувийн хэвшлийн ашгийн төлөө бус байгууллага гэх мэт тохиолдол байж болно. Засгийн газарт шинэ газар хэлтсийг байгуулах гэх мэт засгийн газрын болон улсын секторын байгууллагуудын бүтцийн өөрчлөлтөөр мөн өмчлөлийн хувь оролцоо үүсэж болно. Иймээс УСНББОУСЗ нь өмчлөлийн хувь оролцоог элемент гэж тодорхойлох эсэхийг авч үзсэн. Эздэд хамаарах нөөц (буюу ирээдүйн нөөцийн талаархи нэхэмжлэл)-ийг тодорхойлох нь хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд ач холбогдолтой мэдээллээр хангана гэж УСНББОУСЗ үздэг. Ийм хувь оролцоог цэвэр санхүүгийн байдлын дэд ангиллаар тодорхойлж болно гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Гэхдээ, эзэд болохын хувьд тэдний бүрэн эрхийн хүрээнд эздээс авсан нөөцийн орлогын гүйлгээ болон тэдэнд олгосон зарлагын гүйлгээг орлого, зардал, бусад нөөц, бусад үүргээс ялган зааглах нь ач холбогдолтой гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Иймээс өмчлөлийн хувь оролцоо ба өмчлөлийн хуваарилалтыг элемент гэж тодорхойлдог. Нөөцийн зарим орлогын гүйлгээ ба зарлагын гүйлгээ нь өмчлөлийн хувь оролцооны болон өмчлөлийн хуваарилалтын тодорхойлолтыг хангах эсэх үнэлгээг дэмжих нарийвчилсан заавар удирдамжийг стандартын түвшинд зохих ёсоор боловсруулна.



## **БҮЛЭГ 6: САНХҮҮГИЙН ТАЙЛАН ДАХЬ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ**

### **АГУУЛГА**

---

	Параграф
Хүлээн зөвшөөрөлтийн шалгуур, түүнчлэн тодруулгатай тэдгээрийн холбогдох уялдаа	6.1-6.4
Элементийн тодорхойлолт	6.5-6.6
Хэмжилтийн тодорхойгүй байдал	6.7-6.8
Тодруулга ба хүлээн зөвшөөрөлт	6.9
Үл хүлээн зөвшөөрөлт	6.10
Дүгнэлтийн үндэслэл	

---

## **Хүлээн зөвшөөрөлтийн шалгуур, түүнчлэн тодруулгатай тэдгээрийн холбогдох уялдаа**

- 6.1 Санхүүгийн тайланд элементүүдийг хүлээн зөвшөөрөхийн тулд хангах ёстой шалгуурыг энэ Бүлэгт тодорхойлсон. Хүлээн зөвшөөрөлт гэдэг нь чанарын шинжүүдийг биелүүлэх ба НЗСТ-д тусгах мэдээллийн хязгаарлалтыг харгалзсан тийм байдлаар хэмжиж болох бөгөөд тухайн элементийн тодорхойлолтыг хангах зүйлийг зохих санхүүгийн тайланд харуулсан дүнгүүдэд тусган оруулах үйл явц юм.
- 6.2 Хүлээн зөвшөөрөлтийн шалгуур нь дараах байдалтай байна:
- Тухайн зүйл нь элементийн тодорхойлолтыг хангах;
  - Чанарын шинжүүдийг биелүүлэх ба НЗСТ-д тусгах мэдээллийн хязгаарлагдмал байдлыг харгалзсан тийм байдлаар хэмжиж болохоор байх.
- 6.3 Хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангасан бүх зүйлсийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Элементийн тодорхойлолтыг хангахгүй нөөц буюу үүргийг уг чанарын шинжүүд ба хязгаарлалтуудыг биелүүлэх тийм арга замаар хэмжиж болохоор байвал санхүүгийн тайлагналын зорилтуудыг хангах үүднээс тэдгээрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрнө гэж зарим тохиолдолд УСНББОУС-д мөн тусгайлан зааж болох юм. Бусад нөөц ба бусад үүргийг Бүлэг 5, *Санхүүгийн Тайлангийн Элементүүд*-д авч хэлэлцсэн.
- 6.4 Хүлээн зөвшөөрөлт нь элементийн оршин байдал ба хэмжилттэй холбоотой тодорхойгүй байдлын үнэлгээг агуулсан байдаг. Тодорхойгүй байдал үүсэхэд хүргэх нөхцлүүд хэрэв байгаа бол тэдгээр нь өөрчлөгдөж болох юм. Иймээс тодорхойгүй байдлыг тайлангийн өдөр бүрээр үнэлэх нь чухал ач холбогдолтой юм.

## **Элементийн тодорхойлолт**

- 6.5 Элемент гэж хүлээн зөвшөөрөхийн тулд уг зүйл нь Бүлэг 5-д заасан, элементүүдийн аль нэгний тодорхойлолтыг хангасан байх ёстой. Тухайн тайлангийн өдрөөр бэлэн боломжтой байгаа бүх баримт материал болон нөхцөл байдлыг харгалзан үзэхэд уг зүйл нь тэрхүү элементийн тодорхойлолтын бүх чухал шинж чанарыг хангаж буй талаар төв голч шүүн тунгаалт хийхийн тулд бэлэн боломжтой байгаа нотолгоог харгалзсанаар элементийн оршин байдлын талаархи тодорхойгүй байдлыг авч үздэг.
- 6.6 Хэрэв элемент оршин байгаа гэж тодорхойлсон бол тэрхүү элементийн илэрхийлэх үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөж бий болгох чадварын талаархи тодорхойгүй байдлыг тухайн элементийн хэмжилтээр харгалзан үздэг (6.7 ба 6.8-р параграфыг үзнэ үү). Элемент оршин байгаа бөгөөд түүнийг хүлээн зөвшөөрөх эсэх, уг элемент нь хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангасан хэвээр байгаа эсэх (6.9-р параграфыг үзнэ үү), эсвэл одоо оршин байгаа элементэд өөрчлөлт орсон эсэхийг

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

тодорхойлохын тулд тайлан бэлтгэгч нь бэлэн боломжтой байгаа бүх нотолгоог нягталж шалгах ба үнэлнэ.

### **Хэмжилтийн тодорхойгүй байдал**

- 6.7 Аливаа зүйлийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөхийн тулд тухайн зүйл нь мөнгөн үнэ цэнэтэй байх шаардлагатай. Энэ нь дараах зүйлсийг гүйцэтгэхэд хүргэнэ. Үүнд: хэмжилтийн тохиромжтой суурийг сонгох, тухайн зүйлийн хэмжилт нь чанарын шинжүүдийг биелүүлсэн эсэхийг тодорхойлох, НЗСТ дахь мэдээллийн хязгаарлалтуудыг, үүн дотроо уг хэмжилт нь санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөх зүйлийн хувьд хангалттай хамааралтай ба үнэн зөв илэрхийлэл болох эсэхийг харгалзан үзэх. Хэмжилтийн тохиромжтой суурийн сонголтыг Бүлэг 7, *Санхүүгийн Тайлан дахь Хөрөнгө, Өр Төлбөрийн Хэмжилт*-д авч үзсэн.
- 6.8 Санхүүгийн тайланд толилуулсан олон дүнгүүдийн хэмжилттэй холбоотой тодорхойгүй байдал үүсэж болох юм. Тооцоолол ашиглалт нь нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн чухал хэсэг юм. Хэмжилтийн хамааралтай ба үнэн зөв илэрхийллийн талаархи шийдвэр нь үр дүнгийн муж ба цэгийн тооцоолол гэх мэт арга зүй, түүнчлэн тайлангийн өдрөөр оршин байсан эдийн засгийн нөхцөл байдлын тухай нэмэлт нотолгоо бэлэн боломжтой байгаа эсэхийг харгалзан үздэг. Тодруулга нь уг ашигласан тооцооллын арга зүйн талаархи ач холбогдолтой мэдээллээр хангадаг. Хэдийгээр тооцооллын арга зүйг тайлбарлахын тулд тодруулга хийсэн ч гэсэн нэг цэгийн тооцооллын тодорхойгүй байдлын түвшин нь уг хэмжилтийн хамааралтай ба үнэн зөв илэрхийллийг эргэлзээтэй болгохуйц тийм их хэмжээтэй байх цөөн ховор тохиолдол байж болох юм. Ийм нөхцөл байдалд тухайн зүйлийг хүлээн зөвшөөрөхгүй.

### **Тодруулга ба хүлээн зөвшөөрөлт**

- 6.9 Элементийн тодорхойлолт ба хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангаж байгаа зүйлсийг хүлээн зөвшөөрөхгүй орхигдуулалтыг тухайн нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулга, тэмдэглэл болон бусад дэлгэрэнгүй тайлбар хийснээр засаж залруулж чадахгүй юм. Гэвч тодруулга нь элементийн тодорхойлолтын бүх биш боловч олон шинж чанарыг хангаж буй зүйлсийн талаархи мэдээллээр хангадаг. Элементийн тодорхойлолтыг хангах боловч санхүүгийн тайлагналын зорилтуудад хүрэхийн тулд чанарын шинжүүдийг хангалттай биелүүлэх тийм арга замаар хэмжих боломжгүй зүйлсийн талаархи мэдээллээр тодруулга нь бас хангадаг. Тухайн зүйлийн талаархи мэдлэг нь уг байгууллагын цэвэр санхүүгийн байдлын үнэлгээнд хамааралтай, иймээс санхүүгийн тайлагналын зорилтуудыг биелүүлнэ гэж үзсэн тохиолдолд тодруулга нь тохиромжтой байдаг.

### **Үл хүлээн зөвшөөрөлт**

- 6.10 Үл хүлээн зөвшөөрөлт нь өмнө хүлээн зөвшөөрсөн элементийг санхүүгийн тайлангаас хасах үндэслэл болох өөрчлөлт уг өмнөх тайлангийн өдрөөс хойш гарч тохиолдсон эсэхийг үнэлэх ба хэрэв ийм өөрчлөлт гарч тохиолдсон бол тухайн зүйлийг санхүүгийн тайлангаас хасах үйл явц юм. Элементийн оршин байдлын талаархи тодорхойгүй байдлыг үнэлэхдээ, анхны хүлээн зөвшөөрөлтөд ашигласантай ижил шалгуурыг уг үл хүлээн зөвшөөрөлтийн хувьд ашиглана.

## **Дүгнэлтийн үндэслэл**

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь Онолын Үзэл Баримтлалыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### **Хүлээн зөвшөөрөлт, түүнчлэн элементүүдийн тодорхойлолттой түүний холбогдох уялдаа**

ДҮ6.1. Хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг элементүүдийн тодорхойлолтод нэгтгэн оруулах хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ авч үзсэн. Хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг элементүүдийн тодорхойлолтод оруулах нь тухайн мэдээллийн зүйлийг санхүүгийн тайланд элемент гэж хүлээн зөвшөөрөх эсэхийг үнэлэхдээ харгалзах ёстой бүх хүчин зүйлсийг авч үзэх боломжийг тайлан бэлтгэгч нарт олгоно гэсэн байр суурийг УСНББОУСЗ илэрхийлсэн. Хэдийгээр уг зүйл нь элементийн тодорхойлолтыг хангах ба тухайн элемент нь хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг биелүүлэх эсэхийг тодорхойлохдоо, харгалзах хүчин зүйлс нь давхцдаг боловч УСНББОУСЗ нь хүлээн зөвшөөрөлтийг санхүүгийн тайлагналын процессын тусдаа үе шат гэж үзэх хэрэгтэй гэсэн байр суурьтай байдаг. Яагаад гэвэл, хүлээн зөвшөөрөлт нь элементийн тодорхойлолт хангагдах эсэхээс илүү өргөн хүрээтэй байдаг. Зөвлөлдөх Баримт Бичиг болон Саналын Төсөлд хариулт ирүүлсэн цөөн хүмүүс нь хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг элементийн тодорхойлолтод нэгтгэн оруулахыг дэмжсэн гэдгийг УСНББОУСЗ бас тэмдэглэсэн. Албан үйл ажиллагааны үр дүнд цуглуулсан мэдээг харгалзан үзсэний дараа, УСНББОУСЗ нь элементүүдийн тодорхойлолтыг хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт оруулах хэрэггүй гэж дүгнэсэн.

ДҮ6.2. Элементийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо харгалзан үзэх шаардлагатай тодорхойгүй байдлын хоёр төрөл байдаг. Эхний тодорхойгүй байдал нь элементийн тодорхойлолт хангагдсан эсэх талаархи тодорхойгүй байдал юм. Хоёр дахь буюу хэмжилтийн тодорхойгүй байдал нь чанарын шинжүүдийг биелүүлэх тийм арга маягаар элементийг хэмжиж чадах эсэх тодорхойгүй байдал юм. Элементийн тодорхойлолт хангагдсан гэж тодорхойлсон бол хэмжилтийн тодорхойгүй байдлыг харгалзан үзнэ. Хүлээн зөвшөөрөлт нь нягтлан бодох бүртгэлийн процессын тусдаа үе шат гэж үзсэн тохиолдолд тухайн зүйл нь элементийн тодорхойлолтыг хангах эсэхийг тодорхойлохын тулд элементийн оршин байдлын тодорхойгүй байдлын үнэлгээтэй холбоотой асуудлуудыг авч үзнэ.

### **Элементийн тодорхойлолтыг хангах**

ДҮ6.3. Элементийн оршин байдлын талаархи тодорхойгүй байдлыг авч үзэхдээ, УСНББОУСЗ нь магадлалын стандартчилсан босго шалгуурыг ашиглах, эсвэл элементийн оршин байдлын талаар төв голч шүүн тунгаалт хийхийн тулд бэлэн боломжтой байгаа бүх нотолгоог ашиглах эсэхийг харгалзан үзсэн.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

- ДҮ6.4. Нотолгооны стандартчилсан босго шалгуур нь үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөж бий болгох чадварын орлогын гүйлгээ эсвэл зарлагын гүйлгээ үүсгэх магадлал багатай зүйлсийг шүүн харуулдаг. Ийм зүйлс нь хэдийгээр оршин байх магадлал багатай боловч өндөр мөнгөн үнэ цэнэтэй байж болно. Хариулт өгсөн зарим хүмүүс нь ийм зүйлсийг хүлээн зөвшөөрөхийн оронд тодруулах нь илүү тохиромжтой гэж үзсэн. Тайлан бэлтгэгч нь эдгээр босго шалгуур хангагдах эсэх анхны шүүн тунгаалтыг зөвхөн хийсний дараа, уг элементийг хэрхэн хэмжих хэрэгтэй гэдгийг авч үзэх учраас босго шалгуурыг өртөг зардлын хувьд мөн зөвтгөн баталж болох юм.
- ДҮ6.5. Үр өгөөжийн гүйлгээний магадлалын харьцангуй бага зөрүүд үндэслэн ижил төсөөтэй мэдээллийн зүйлсийг өөр өөр арга замаар авч үзэж болох учраас хүлээн зөвшөөрөлтийн зорилгоор босго шалгуур хэрэглэх нь хамааралтай ба үнэн зөв илэрхийлэл болох мэдээллийг орхигдуулах эрсдэлтэй гэсэн байр суурийг УСНББОУСЗ илэрхийлсэн. Хүлээн зөвшөөрөлтийн босго шалгуурыг тусгайлан заагаагүй арга хандлагын хувьд мөн ийм эрсдэл оршин байна гэдгийг УСНББОУСЗ мэдэгдсэн. Яагаад гэвэл, тайлан бэлтгэгч нар нь хүлээн зөвшөөрөлтийг зөвтгөн дэмжих нөхцөл байдал буюу “босго шалгуур”-ын талаархи өөрсдийн үнэлгээг хийх бөгөөд тэдгээр үнэлгээ нь өөр өөр зүйлсийн хувьд болон цаг хугацааны явцад өөрчлөгдөж болох юм. Гэвч элемент оршин буй эсэхийг тодорхойлох бэлэн боломжит бүх нотолгооны үнэлгээнд үндэслэсэн бөгөөд үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөж бий болгох чадварын талаархи тодорхойгүй байдлыг хэмжилтэнд харгалзан үзсэн арга хандлага нь санхүүгийн тайлан бэлтгэгч нарт тулгардаг тодорхойгүй асуудлын хувьд ерөнхийдөө хамгийн тохиромжтой хариулт болдог гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Энэ нь даган мөрдөх ёстой, санамсаргүй тохиолдлын шинжтэй босго шалгуур тогтоохын оронд, чанарын шинжүүдийг хангасан тийм мэдээллийн хүлээн зөвшөөрөлтөнд хүргэх илүү их магадлалтай юм. Тухайн нөхцөл байдалд элемент оршин буй эсэх, ингэснээр хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангах талаар мэдэгдэхүйц тодорхойгүй байдал бүхий тийм нөхцөл байдлыг зохицуулах заавар удирдамжийг стандартын түвшинд ханган бүрдүүлж болох юм.
- ДҮ6.6. Элементийн оршин байдлын талаархи тодорхойгүй байдал нь хөрөнгө, өр төлбөрийн зарим шинж чанаруудад, тухайлбал; байгууллага нь нөөцийн эрхийг хянадаг хөрөнгийн хувьд, эсвэл байгууллага нь үйлчилгээний чадавхи болон эдийн засгийн үр өгөөжийн гадагш зарцуулалтаас зайлсхийх бодит боломжгүй буюу боломж багатай өр төлбөрийн хувьд тусгайлан хамаарах эсэхийг УСНББОУСЗ судалж үзсэн. Ингэж авч үзэх үндсэн шалтгаан нь эдгээр шинжүүд бол тодорхойгүй байдал үүсэх магадлалтай хөрөнгө, өр төлбөрийн чухал шинжүүд болдог явдал юм.
- ДҮ6.7. Тодорхойгүй байдал нь зөвхөн эдгээр шинж чанаруудаас илүү олон зүйлстэй холбоотой гэж УСНББОУСЗ үздэг. Өр төлбөрийн хувьд одоогийн үүрэг ба өнгөрсөн үйл явдал оршин буй эсэх, хөрөнгийн хувьд ирээдүйн нөөц буюу нөөцийн ирээдүйн эрхээс гадна ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг одоо бий болгох нөөц оршин буй эсэх

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТой  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

нь мөн тодорхойгүй байж болох юм. ДҮ6.2-р параграфт дурдсанчлан, тухайн зүйл нь элементийн тодорхойлолтыг хангах эсэхийг тодорхойлохын тулд эдгээр асуудлуудыг мөн харгалзан үзнэ.

**Үл хүлээн зөвшөөрөлт**

ДҮ6.8. УСНББОУСЗ нь анхны хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлтийн хувьд нэг ижил шалгуур ашиглах хэрэгтэй эсэхийг авч үзсэн. Зөвлөлдөх Баримт Бичиг болон Саналын Төсөлд хариулт ирүүлсэн олон хүмүүс нь анхны хүлээн зөвшөөрөлтөд ашигласантай ижил шалгуурыг үл хүлээн зөвшөөрөлтөд ашиглахыг дэмжсэн. Хүлээн зөвшөөрөлтийн ялгаатай шалгуур ашиглах нь тэдгээрийн оршин байдлын хувьд нотолгооны өөр өөр стандарт бүхий зүйлсийг хүлээн зөвшөөрөхөд хүргэх тул тууштай байдал гэсэн чанарын шинжтэй зөрчилдөнө гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Иймээс анхны хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлтийн хувьд нэг ижил шалгуур ашиглах хэрэгтэй.

## БҮЛЭГ 7: САНХҮҮГИЙН ТАЙЛАН ДАХЬ ХӨРӨНГӨ, ӨР ТӨЛБӨРИЙН ХЭМЖИЛТ

### АГУУЛГА

---

	Параграф
Танилцуулга	7.1
Хэмжилтийн зорилго	7.2-7.12
Хэмжилтийн сууриуд ба тэдгээрийн сонголт	7.5-7.7
Орох ба гарах үнэ цэнэ	7.8-7.9
Ажиглаж болох ба ажиглаж үл болох хэмжүүр	7.10
Байгууллагын тусгайлсан ба байгууллагын тусгайлсан бус хэмжүүр	7.11
Хэмжилтийн хувьд нэгтгэн нийлүүлэх эсвэл салган задлах түвшин	7.12
Хөрөнгийн хэмжилтийн сууриуд	7.13-7.68
Түүхэн өртөг	7.13-7.21
Одоогийн үнэ цэнийн хэмжилт	7.22-7.23
Зах зээлийн үнэ цэнэ	7.24-7.36
Орлуулалтын өртөг	7.37-7.48
Борлуулалтын цэвэр үнэ	7.49-7.57
Ашиглалтын үнэ цэнэ	7.58-7.68
Өр төлбөрийн хэмжилтийн сууриуд	7.69-7.91
Түүхэн өртөг	7.70-7.73
Гүйцэтгэлийн өртөг	7.74-7.79
Зах зээлийн үнэ цэнэ	7.80-7.81
Чөлөөлөгдөх өртөг	7.82-7.86
Үүрэг хариуцсаны үнэ	7.87-7.91
Дүгнэлтийн үндэслэл	

---



## Танилцуулга

- 7.1 Холбогдох шаардлагуудыг УСНББОУС-д заагаагүй тохиолдолд УСНББОУС-уудын хувьд хэмжилтийн суурийг УСНББОУСЗ сонгоход, түүнчлэн хөрөнгө, өр төлбөрийн хувьд хэмжилтийн суурийг санхүүгийн тайлан бэлтгэгч нар сонгоход удирдамж болох хэмжилтийн тухай ойлголт ухагдахууныг энэ Бүлэгт тодорхойлсон.

## Хэмжилтийн зорилго

- 7.2 Хэмжилтийн зорилго нь:

*Тухайн байгууллагын үйлчилгээний өртөг, үйл ажиллагааны чадавхи, санхүүгийн чадавхийг хамгийн үнэн зөв тусгах ба ингэснээр тайлагналын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд уг байгууллагад ач холбогдолтой байдлаар тэдгээр хэмжилтийн суурийг сонгох явдал юм.*

- 7.3 Хөрөнгө, өр төлбөрийн хэмжилтийн суурийн сонголт нь дараах зүйлсийг үнэлэх боломжийг хэрэглэгчдэд олгох мэдээллээр хангаснаар улсын сектор дахь санхүүгийн тайлагналын зорилтуудыг биелүүлэхэд хувь нэмрээ оруулдаг. Үүнд:

- Тайлант үед үзүүлсэн үйлчилгээний өртөг нь түүхэн эсвэл одоогийн өртгөөр илэрхийлэгдсэн эсэх;
- Үйл ажиллагааны чадавхи - Ирээдүйн тайлант үеүдэд үзүүлэх үйлчилгээг биет болон бусад нөөцөөр дэмжих уг байгууллагын чадавхи;
- Санхүүгийн чадавхи – Өөрийн үйл ажиллагааг санхүүжүүлэх тухайн байгууллагын чадавхи.

- 7.4 Хэмжилтийн суурийн сонголт нь санхүүгийн тайлан дахь мэдээллийн хязгаарлалтыг харгалзахын зэрэгцээгээр чанарын шинжүүдийг биелүүлэх мэдээллээр хангах хэмжээ зэргийн талаархи үнэлгээг бас агуулсан байдаг.

## Хэмжилтийн сууриуд ба тэдгээрийн сонголт

- 7.5 Хэмжилтийн зорилтыг хамгийн сайн хангах нэг хэмжилтийн суурийг Онолын үзэл баримтлалын түвшинд тодорхойлох боломжгүй юм. Иймээс Онолын үзэл баримтлал нь бүх ажил гүйлгээ, үйл явдал, нөхцөл байдлын хувьд ганц хэмжилтийн суурийг (буюу сууриудын хослолыг) санал болгодоггүй. Харин энэ нь хэмжилтийн зорилтыг хангахын тулд хөрөнгө, өр төлбөрийн хэмжилтийн суурийг сонгох заавар удирдамжаар хангадаг.

- 7.6 Хөрөнгийн хувьд дараах хэмжилтийн сууриудыг тодорхойлж, байгууллагын үзүүлсэн үйлчилгээний өртөг, байгууллагын үйл ажиллагааны чадавхи болон санхүүгийн чадавхийн талаар эдгээр сууриудын хангах мэдээлэл, түүнчлэн чанарын шинжүүдийг биелүүлэх мэдээллээр хангах хэмжээний хувьд эдгээр сууриудыг авч хэлэлцсэн:

**УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

- Түүхэн өртөг;
- Зах зээлийн үнэ цэнэ;
- Орлуулалтын өртөг;
- Борлуулалтын цэвэр үнэ;
- Ашиглалтын үнэ цэнэ.

Эдгээр хэмжилтийн сууриуд нь (а) орох эсвэл гарах үнэ цэнээр хангах эсэх, (б) эдгээрийг зах зээл дээр ажиглаж болох эсэх; (в) эдгээр нь байгууллагын тусгайлсан шинжтэй, үгүй эсэхээр Хүснэгт 1-д тоймлон харуулав.<sup>8</sup>

**Хүснэгт 1. Хөрөнгийн хэмжилтийн сууриудын тойм**

<b>Хэмжилтийн суурь</b>	<b>Орох эсвэл гарах</b>	<b>Зах зээлд ажиглаж болох эсвэл ажиглаж үл болох</b>	<b>Байгууллагын тусгайлсан эсвэл тусгайлсан бус</b>
Түүхэн өртөг	Орох	Ерөнхийдөө ажиглаж болох	Байгууллагын тусгайлсан
Нээлттэй, идэвхитэй, хэвийн зах зээл дэх зах зээлийн үнэ цэнэ	Орох ба гарах	Ажиглаж болох	Байгууллагын тусгайлсан бус
Идэвхигүй зах зээл дэх зах зээлийн үнэ цэнэ	Гарах	Үнэлгээний арга зүйгээс хамаарах	Үнэлгээний арга зүйгээс хамаарах
Орлуулалтын өртөг	Орох	Ажиглаж болох	Байгууллагын тусгайлсан
Борлуулалтын цэвэр үнэ	Гарах	Ажиглаж болох	Байгууллагын тусгайлсан
Ашиглалтын үнэ цэнэ	Гарах <sup>9</sup>	Ажиглаж үл болох	Байгууллагын тусгайлсан

7.7 Өр төлбөрийн хувьд дараах хэмжилтийн сууриудыг тодорхойлж, (а) байгууллагын үзүүлсэн үйлчилгээний өртөг, байгууллагын үйл ажиллагааны чадавхи болон санхүүгийн чадавхийн талаар эдгээр сууриудын хангах мэдээлэл, (б) чанарын шинжүүдийг биелүүлэх мэдээллээр хангах хэмжээний хувьд эдгээр сууриудыг авч хэлэлцсэн:

- Түүхэн өртөг;
- Гүйцэтгэлийн өртөг;

<sup>8</sup> Тухайн хэмжилтийн суурийг зах зээл дээр ажиглаж болох эсвэл ажиглаж үл болох, байгууллагын тусгайлсан эсвэл тусгайлсан бус шинжтэй гэж ангилахдаа зарим тохиолдолд шүүн тунгаалт хийдэг.

<sup>9</sup> 7.66-р параграфт заасанчлан, мөнгө бий болгодоггүй хөрөнгийн хувьд ашиглалтын үнэ цэнийн тооцоолол нь орлох зүйл болгон орлуулалтын өртгийг ашиглахыг шаардаж болох юм.

**УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

- Зах зээлийн үнэ цэнэ;
- Чөлөөлөгдөх өртөг;
- Үүрэг хариуцсаны үнэ.

Эдгээр хэмжилтийн сууриуд нь (а) орох эсвэл гарах үнэ цэнээр хангах эсэх, (б) эдгээрийг зах зээл дээр ажиглаж болох эсэх; (в) эдгээр нь байгууллагын тусгайлсан шинжтэй, үгүй эсэхээр Хүснэгт 2-т тоймлон харуулав.

**Хүснэгт 2. Өр төлбөрийн хэмжилтийн сууриудын тойм**

<b>Хэмжилтийн суурь</b>	<b>Орох эсвэл гарах</b>	<b>Зах зээлд ажиглаж болох эсвэл ажиглаж үл болох</b>	<b>Байгууллагын тусгайлсан эсвэл тусгайлсан бус</b>
Түүхэн өртөг	Орох	Ерөнхийдөө ажиглаж болох	Байгууллагын тусгайлсан
Гүйцэтгэлийн өртөг	Гарах	Ажиглаж үл болох	Байгууллагын тусгайлсан
Нээлттэй, идэвхитэй, хэвийн зах зээл дэх зах зээлийн үнэ цэнэ	Орох ба гарах	Ажиглаж болох	Байгууллагын тусгайлсан бус
Идэвхигүй зах зээл дэх зах зээлийн үнэ цэнэ	Гарах	Үнэлгээний арга зүйгээс хамаарах	Үнэлгээний арга зүйгээс хамаарах
Чөлөөлөгдөх өртөг	Гарах	Ажиглаж болох	Байгууллагын тусгайлсан
Үүрэг хариуцсаны үнэ	Орох	Ажиглаж болох	Байгууллагын тусгайлсан

**Орох ба гарах үнэ цэнэ**

7.8 Хэмжилтийн сууриуд нь орох эсвэл гарах үнэ цэнээр хангаж болох юм. Хөрөнгийн хувьд, орох үнэ цэнэ нь худалдан авалтын өртгийг илэрхийлдэг. Түүхэн өртөг ба орлуулалтын өртөг нь орох үнэ цэнэ юм. Гарах үнэ цэнэ нь борлуулалтаас үүсэх эдийн засгийн үр өгөөжийг илэрхийлдэг. Гарах үнэ цэнэ нь хөрөнгийн ашиглалтаас үүсэх дүнг бас тусгадаг. Олон төрөлт эдийн засгийн орчинд, байгууллагууд нь ихэвчлэн дараах байдлаар ажилладаг тул орох ба гарах үнэ цэнэ нь өөр хоорондоо ялгаатай байдаг.

- Зах зээлийн бусад оролцогч нар ижил төсөөтэй үнэ төлөхөд бэлэн бус байх уг байгууллагын үйл үйл ажиллагааны тухайн тодорхой шаардлагуудад нийцүүлэн хөрөнгийг олж эзэмших;
- Худалдан авалтын хувьд ажил гүйлгээний зардлыг гаргах.

7.9 Өр төлбөрийн хэмжилтийн сууриудыг орох үнэ цэнэ эсвэл гарах үнэ цэнэ гэдгээр бас ангилж болно. Орох үнэ цэнэ нь үүргийг хүлээн авах ажил гүйлгээ буюу өр төлбөрийг хариуцахын тулд байгууллагын хүлээн зөвшөөрөх дүнтэй холбоотой байдаг. Гарах үнэ цэнэ нь үүргийг

## УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

биелүүлэхэд шаардагдах дүн буюу үүргээс тухайн байгууллагыг чөлөөлөхөд шаардлагатай дүнг тусгадаг.

### **Ажиглаж болох ба ажиглаж үл болох хэмжүүр**

7.10 Зарим хэмжүүрийг нээлттэй, идэвхитэй, хэвийн зах зээлд ажиглаж болох эсэхээр ангилж болно.<sup>10</sup> Зах зээл дээр ажиглаж болох хэмжүүр нь ажиглаж үл болох хэмжүүрээс илүү ойлгомжтой бөгөөд шалгах боломжтой байх магадлалтай юм. Эдгээр нь өөрийн хэмжиж буй юмс үзэгдлийг мөн илүү үнэн зөв илэрхийлж болох юм.

### **Байгууллагын тусгайлсан ба байгууллагын тусгайлсан бус хэмжүүр**

7.11 Хэмжүүрийг мөн “байгууллагын тусгайлсан” эсвэл “байгууллагын тусгайлсан бус” эсэхээр ангилж болно. Байгууллагын тусгайлсан хэмжилтийн сууриуд нь тухайн байгууллагын хөрөнгийн боломжит ашиглалт ба өр төлбөрийн барагдуулалтад нөлөөлдөг эдийн засгийн болон одоогийн бодлогын хязгаарлалтуудыг тусгадаг. Байгууллагын тусгайлсан хэмжүүр нь бусад байгууллагуудад бэлэн боломжтой байдаггүй эдийн засгийн боломж болон бусад байгууллагуудад үл учрах эрсдлийг илэрхийлж болох юм. Байгууллагын тусгайлсан бус хэмжүүр нь зах зээлийн ерөнхий боломж ба эрсдлийг тусгасан байдаг. Хэмжилтийн зорилт болон чанарын шинжүүдийг лавлагаа болгон харгалзсанаар байгууллагын тусгайлсан эсвэл байгууллагын тусгайлсан бус хэмжүүрийг ашиглах эсэх шийдвэрийг гаргадаг.

### **Хэмжилтийн хувьд нэгтгэн нийлүүлэх эсвэл салган задлах түвшин**

7.12 Хэмжилтийн зорилтыг хамгийн сайн хангах ба чанарын шинжүүдийг биелүүлэх мэдээлэл бэлтгэх тийм арга замаар хөрөнгө, өр төлбөрийг санхүүгийн тайланд толилуулахын тулд тэдгээрийг хэмжилтийн зорилгоор нэгтгэн нийлүүлэх эсвэл салган задлах шаардлагатай байж болно. Ийм нэгтгэн нийлүүлэлт эсвэл салган задлалт нь тохиромжтой эсэхийг үнэлэхдээ, өртөг зардлыг үр өгөөжтэй харьцуулж үздэг.

### **Хөрөнгийн хэмжилтийн сууриуд**

#### **Түүхэн өртөг**

7.13 Хөрөнгийн хувьд түүхэн өртөг гэдэг нь:

*Хөрөнгийг олж эзэмших буюу хөгжүүлэхийн тулд төлсөн төлбөр, энэ нь түүний олж эзэмшилт буюу хөгжүүлэлтийн хугацаанд өгсөн мөнгө буюу мөнгөтэй адилтгах хөрөнгө болон бусад зүйлийн бодит үнэ цэнэ юм.*

---

<sup>10</sup> “Нээлттэй, идэвхитэй, хэвийн зах зээл” гэсэн нэр томъёог доктор Жей Алекс Милбурн боловсруулсан. Тухайлбал; Канадын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институтээс 2012 онд хэвлүүлсэн, “Ашгийн төлөө байгууллагуудын Хэмжилтийн Үзэл Баримтлалд” бүтээлийг үзнэ үү.

- 7.14 Түүхэн өртөг нь байгууллагын тусгайлсан, орох үнэ цэнэ юм.<sup>11</sup> Түүхэн өртгийн загварын дагуу, хөрөнгийг түүний олж эзэмшилтийн хувьд зарцуулсан өртгөөр эхлээд тайлагнана. Зарим хөрөнгүүдийн бүрдүүлэх үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөж бий болгох чадвар нь тэдгээрийн ашиглалтын хугацааны туршид зарцуулагдан ашиглагдах учраас анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, энэхүү өртгийг тэдгээр хөрөнгийн элэгдэл буюу хорогдуулга хэлбэрээр тайлант үеүдэд зардал байдлаар хуваарилж болно. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, тухайн хөрөнгийн үнийн өөрчлөлт буюу үнэ цэнийн өсөлтийг тусгахын тулд түүний хэмжилтийг өөрчлөхгүй.
- 7.15 Түүхэн өртгийн загварын дагуу, хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрөх замаар түүний дүнг бууруулж болно. Үнэ цэнийн бууралт нь хөрөнгийн ашиглан зарцуулалтад хамааралгүй эдийн засгийн болон бусад нөхцөл байдлын өөрчлөлтийн улмаас түүний ханган бүрдүүлэх, үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөж бий болгох чадварын багасан буурах хэмжээ юм. Энэ нь нөхөгдөх байдлын үнэлгээг агуулдаг. Харин эсрэгээр, нэмэлт өргөтгөл болон сайжруулалт, эсвэл санхүүгийн хөрөнгийн хувьд хүүний хуримтлуулалт гэх мэт бусад үйл явдлын өртгийг тусгахын тулд хөрөнгийн дүнг нэмэгдүүлж болно (сайжруулалт хийгдээгүй хөрөнгийн үнийн өсөлт үүнд хамаарахгүй).

#### *Үйлчилгээний өртөг*

- 7.16 Түүхэн өртгийг хэрэглэх тохиолдолд үйлчилгээний өртөг нь тухайн үйлчилгээг үзүүлэхдээ ашигласан хөрөнгийг олж эзэмших буюу хөгжүүлэхэд зарцуулсан нөөцийн дүнг тусгадаг. Түүхэн өртөг нь тухайн байгууллагын бодитойгоор гүйцэтгэсэн ажил гүйлгээтэй ерөнхийдөө шууд уялдаа холбоотой байдаг. Ашигласан өртөг нь үнийн өөрчлөлтийн хувьд тохируулга хийгээгүй, өмнөх тайлант үеэс шилжсэн дүн байх учраас энэ нь тухайн хөрөнгийг ашиглах үеийн түүний өртгийг тусган илэрхийлдэггүй. Өнгөрсөн хугацааны үнийг ашигласнаар үйлчилгээний өртгийг тайлагнадаг тул түүний анхны олж эзэмшилтээс хойшхи үнийн хуримтлагдсан өөрчлөлт нь мэдэгдэхүйц дүнтэй байсан гэсэн уг түүхэн өртгийн мэдээлэл нь үйлчилгээг үзүүлэх ирээдүйн өртөг зардлын талаархи тооцооллод туслалцаа үзүүлэхгүй. Төсвийг түүхэн өртгийн сууриар бэлтгэдэг тохиолдолд уг түүхэн өртгийн мэдээлэл нь төсвийн гүйцэтгэлийн хэмжээг илтгэн харуулдаг.

#### *Үйл ажиллагааны чадавхи*

- 7.17 Хэрэв хөрөнгийг арилжааны ажил гүйлгээгээр олж эзэмшсэн бол түүхэн өртөг нь түүний олж эзэмшилтийн өртөгт үндэслэн ирээдүйн тайлант үеүдэд үйлчилгээ үзүүлэх бэлэн боломжтой байгаа нөөцийн талаархи мэдээллээр хангадаг. Хөрөнгийг худалдан авах буюу хөгжүүлэх үед тухайн байгууллагад бий болох түүний үйлчилгээний чадавхийн үнэ цэнэ наад зах

---

<sup>11</sup> “Түүхэн өртөг” нэр томъёог “өртгийн загвар” буюу ерөнхийдөө “өртөгт суурилсан хэмжүүр” байдлаар бас илэрхийлж болно.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

нь, уг худалдан авалтын өртгөөс илүү байна гэж төсөөлж болох юм.<sup>12</sup> Элэгдэл буюу хорогдуулгыг хүлээн зөвшөөрөх үед энэ нь тухайн хөрөнгийн үйлчилгээний чадавхийн ашиглан зарцуулсан хэмжээг тусган харуулдаг. Ирээдүйн үйлчилгээ үзүүлэхэд бэлэн боломжтой байгаа нөөц наад зах нь, түүний бүртгэсэн дүнгээс илүү байна гэдгийг түүхэн өртгийн мэдээлэл харуулдаг. Түүхэн өртгийн загвар нь хөрөнгийн үнэ цэнийн өсөлтийг тусган илэрхийлдэггүй. Хэрэв хөрөнгийг арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн бол уг ажил гүйлгээний үнэ нь үйл ажиллагааны чадавхийн талаархи мэдээллээр хангахгүй.

*Санхүүгийн чадавхи*

7.18 Хөрөнгийг санхүүгийн тайланд тусгадаг дүн нь санхүүгийн чадавхийг үнэлэхэд тусгалцаа үзүүлдэг. Түүхэн өртөг нь зээлийн үр дүнтэй хамгаалалт байдлаар ашиглаж болох уг хөрөнгийн дүнгийн талаархи мэдээллээр хангадаг. Санхүүгийн чадавхийн үнэлгээ нь хөрөнгийн борлуулалтаар хүлээн авч болох, түүнчлэн өөр үйлчилгээ үзүүлэхийн тулд тухайн хөрөнгөнд дахин хөрөнгө оруулалт хийж болох дүнгийн талаархи мэдээллийг бас шаарддаг. Одоогийн гарах үнэ цэнээс мэдэгдэхүйц өөр байх тохиолдолд түүхэн өртөг нь ийм мэдээллээр хангадаггүй.

*Чанарын шинжүүдийг ашиглах*

7.19 Түүхэн өртөг нь өөрийн баталгаажуулах буюу таамаглах үнэ цэнийн хувьд хамааралтай мэдээллээр хангах талбаруудыг 7.16-7.18-р параграфт тайлбарласан. Ажил гүйлгээний мэдээлэл нь ихэвчлэн бэлэн боломжтой байдаг учраас түүхэн өртгийг ашиглахад ямагт хялбар байдаг. Иймээс түүхэн өртгийн загвараар олж авсан дүн нь өөрийн төлөөлөн илэрхийлэхийг зорьж буй зүйлийг ерөнхийдөө үнэн зөв илэрхийлдэг - өөрөөр хэлбэл, хөрөнгийг олж эзэмших буюу хөгжүүлэх өртөг нь бодит ажил гүйлгээнд үндэслэдэг. Түүхэн өртгийн загварт, ялангуяа мөнгө бий болгодоггүй хөрөнгийн хувьд ашигласан элэгдэл ба үнэ цэнийн бууралтын тооцоолол нь төлөөлөн илэрхийллийн үнэн зөв байдалд нөлөөлдөг. Түүхэн өртөг ашиглалт нь бодит ажил гүйлгээг лавлагаа болгосноор тухайн зарцуулсан нөөцийг ерөнхийдөө тусган харуулдаг учраас түүхэн өртгийн хэмжүүр нь шалгах боломжтой, ойлгомжтой бөгөөд түүнийг цаг хугацаанд нь бэлтгэх боломжтой байдаг.

7.20 Хөрөнгүүд нь олж эзэмшилтийн нэг ижил буюу ойролцоо өдрүүдтэй байх хэмжээгээр түүхэн өртгийн мэдээллийг зэрэгцүүлэх боломжтой байдаг. Түүхэн өртөг нь үнийн өөрчлөлтийн нөлөөг тусгадаггүй учраас үнэ мэдэгдэхүйц хэмжээгээр өөрчлөгдсөн тохиолдолд янз бүрийн хугацаанд олж эзэмшсэн хөрөнгүүдийн дүнг зэрэгцүүлэх боломжгүй байдаг.

---

<sup>12</sup> Ийм биш байх тохиолдолд уг үнэ цэнийн бууралтын дүнгээр түүхэн өртгийн анхны хэмжилтийг бууруулна.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

7.21 Түүхэн өртгийн ашиглалт нь зарим нөхцөл байдалд тухайлбал, дараах тохиолдолд хуваарилалт хийхийг зайлшгүй шаарддаг:

- Хэд хэдэн хөрөнгийг нэг ажил гүйлгээгээр олж эзэмших;
- Байгууллага нь хөрөнгийг өөрөө барьж байгуулсан бөгөөд үйлдвэрлэлийн нэмэгдэл болон бусад өртөг зардлыг хуваарилах шаардлагатай байх; ба
- Ижил төсөөтэй олон хөрөнгийг эзэмшиж байгаа тохиолдолд, эхэлж авсныг эхэлж зарлагадах гэх мэт өртгийн төсөөллийг ашиглах шаардлагатай байх. Ийм хуваарилалт нь санамсаргүй тохиолдлын шинжтэй байх хэмжээгээр түүний үр дүн болох хэмжилт нь чанарын шинжүүдийг биелүүлэх магадлал багасдаг.

**Одоогийн үнэ цэнийн хэмжилт**

7.22 Одоогийн үнэ цэнийн хэмжилт нь тухайн тайлангийн өдрөөрх гол зонхилох эдийн засгийн орчинг тусган илэрхийлдэг.

7.23 Хөрөнгийн хувьд одоогийн үнэ цэнийн хэмжилтийн дараах дөрвөн суурь байдаг:

- Зах зээлийн үнэ цэнэ;
- Орлуулалтын өртөг;
- Борлуулалтын цэвэр үнэ;
- Ашиглалтын үнэ цэнэ.

**Зах зээлийн үнэ цэнэ**

7.24 Хөрөнгийн хувьд зах зээлийн үнэ цэнэ гэдэг нь:

*Зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хоорондох харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгийг арилжиж болох дүн юм.*

7.25 Хэрэв ажил гүйлгээний зардлыг харгалзахгүй бөгөөд тухайн ажил гүйлгээ нь арилжааны ажил гүйлгээ бол олж эзэмшилтийн үеийн зах зээлийн үнэ цэнэ ба түүхэн өртөг нь ижил байна. Зах зээлийн үнэ цэнэ нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг хангах хэмжээ ба хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээ нь тухайн зах зээлийн нотолгооны чанараас зарим талаар хамаардаг. Нөгөө талаас, зах зээлийн нотолгоо нь тухайн хөрөнгийг арилждаг зах зээлийн шинж чанараас хамаардаг. Орох ба гарах үнэ цэнүүдийн хоорондох зөрүү нь мэдэгдэхүйц хэмжээтэй байх магадлал багатай буюу тухайн хөрөнгийг борлуулах зорилгоор эзэмшиж байгаа гэж үзсэн тохиолдолд зах зээлийн үнэ цэнэ нь илүү тохиромжтой байдаг.

7.26 Зарчмын хувьд, зах зээлийн үнэ цэнэ нь тухайн байгууллага дахь хөрөнгийн үнэ цэнийг үнэн зөв тусган илэрхийлдэг учраас ач холбогдолтой мэдээллээр хангадаг. Нээлттэй, идэвхитэй, хэвийн зах зээлд (7.28-р

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

параграфыг үзнэ үү), тухайн хөрөнгө нь түүнийг борлуулснаар уг байгууллагын олж авах дүн болох зах зээлийн үнээс бага үнэ цэнэтэй байх боломжгүй бөгөөд тэрхүү хөрөнгийг худалдан авснаар байгууллагын олж авах адилтгах үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөж бий болгох чадвар болох зах зээлийн үнээс илүү үнэ цэнэтэй байх боломжгүй юм.

7.27 Нээлттэй, идэвхитэй, хэвийн зах зээл гэж төсөөлөх боломжгүй тохиолдолд зах зээлийн үнэ цэнийн ач холбогдол эргэлзээтэй байдаг. Ийм нөхцөл байдалд тухайн хөрөнгийг олж эзэмших уг үнээр борлуулж болно гэж төсөөлж болохгүй бөгөөд гарах үнэ цэнэ эсвэл орох үнэ цэнэ нь илүү ач холбогдолтой хэмжүүр эсэхийг тодорхойлох шаардлагатай байдаг. Гарах үнэ цэнэд үндэслэсэн зах зээлийн үнэ нь зарим санхүүгийн хэрэглүүр гэх мэт худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй хөрөнгийн хувьд ач холбогдолтой боловч тусгайлсан үйл ажиллагааны хөрөнгийн хувьд ач холбогдолгүй байж болно. Түүнчлэн, хөрөнгийн худалдан авалт нь тухайн байгууллага дахь уг хөрөнгийн үнэ цэнэ наад зах нь, түүний худалдан авалтын үнээс илүү гэсэн нотолгоогоор хангахаас гадна, үйл ажиллагааны хүчин зүйлс нь байгууллага дахь тэрхүү үнэ цэнэ үүнээс илүү их гэдгийг илэрхийлж болох юм. Иймээс зах зээлийн үнэ цэнэ нь түүний үйл ажиллагааны чадавхиар илэрхийлэгдэх уг хөрөнгийн тухайн байгууллага дахь үнэ цэнийг тусган илэрхийлэхгүй байж болно.

*Нээлттэй, идэвхитэй, хэвийн зах зээл дэх зах зээлийн үнэ цэнэ*

7.28 Нээлттэй, идэвхитэй, хэвийн зах зээл нь дараах шинж чанартай байдаг:

- Зах зээлд тухайн байгууллага ажил гүйлгээ хийхээс сэргийлсэн саад хязгаарлалт байдаггүй;
- Зах зээл нь идэвхитэй, иймээс үнийн мэдээллээр хангах хангалттай давтамж ба тоо хэмжээ бүхий ажил гүйлгээтэй байдаг;
- Зах зээл нь албадлагагүйгээр оролцдог, сайн мэдээлэл бүхий олон худалдан авагч ба борлуулагчтай хэвийн зах зээл байдаг. Иймээс одоогийн үнийг тодорхойлоход “шударга” хандсан, үүн дотроо тэдгээр үнэ нь албадсан борлуулалтыг илэрхийлээгүй гэсэн баталгаатай байх.

Хэвийн зах зээл нь найдвартай, аюулгүй, үнэн зөв ба үр ашигтай байдлаар арилжаа хийдэг зах зээл юм. Үнэ нь олон нийтэд нээлттэй, ил тод байх тохиолдолд өргөн хэрэглээний бараа, валют, үнэт цаас гэх мэт ижил төсөөтэй, иймээс харилцан солилцож болох хөрөнгүүдийг ийм зах зээлд арилждаг. Практикт хэрэв байдаг гэхэд маш цөөн зах зээл нь эдгээр бүх шинж чанаруудыг бүрэн илэрхийлэн харуулдаг боловч зарим зах зээл нь ингэж тодорхойлсон хэвийн зах зээлд дөхөж очсон байж болох юм.



УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

*Зах зээлийг нээлттэй, идэвхитэй, хэвийн гэж үзэх боломжгүй тохиолдол дахь зах зээлийн үнэ цэнэ*

7.29 Өвөрмөц бөгөөд маш ховор арилжаалагддаг хөрөнгийн хувьд түүний зах зээл нь нээлттэй, идэвхитэй, хэвийн биш байдаг: аливаа худалдан авалт ба борлуулалтыг тус тусад нь хэлэлцэн тохирох бөгөөд ажил гүйлгээг зөвшөөрч болох үнийн өргөн мужтай байж болох юм. Иймээс оролцогчид нь хөрөнгийг худалдан авах буюу борлуулахдаа мэдэгдэхүйц их өртөг зардал гаргадаг. Ийм нөхцөл байдалд, одоогийн зах зээлийн нөхцлийн дагуу хэмжилтийн өдөр тэдгээр зах зээлийн оролцогчдын хооронд тухайн хөрөнгийг борлуулах хэвийн ажил гүйлгээг хийх үнийг тооцоолохын тулд тооцооллын арга зүй ашиглах шаардлагатай байдаг.

*Үйлчилгээний өртөг*

7.30 Санхүүгийн тайланд тайлагнасан үйлчилгээний орлогыг тухайн тайлант үед оршин байсан үнүүдэд үндэслэн хэмждэг. Үйлчилгээ үзүүлэхэд ашигласан хөрөнгийг зах зээлийн үнээр хэмждэг бол тухайн тайлант үе дэх тэдгээр хөрөнгийн ашиглан зарцуулалтыг тусгах түүний өртгийн хуваарилалт нь уг хөрөнгийн одоогийн зах зээлийн үнэ цэнэд үндэслэдэг.

7.31 Зах зээлийн үнэ цэнийг ашиглах нь хөрөнгийн өгөөжийг тодорхойлох боломж олгодог. Гэвч улсын секторын байгууллагууд нь ашиг олох үндсэн зорилго бүхий үйл ажиллагааг ерөнхийдөө эрхлэн явуулдаггүй бөгөөд үйлчилгээг ихэвчлэн арилжааны бус ажил гүйлгээгээр буюу хөнгөлттэй нөхцлөөр үзүүлдэг. Иймээс гарах үнэ цэнэд үндэслэсэн зах зээлийн үнээс бий болсон, тайлагнасан өгөөж нь хамааралтай байдлын хувьд хязгаарлагдмал байж болох юм.

7.32 Дээр дурдсанчлан, санхүүгийн тайланд тайлагнасан үйлчилгээний орлогыг тухайн тайлант үед оршин байсан үнүүдэд үндэслэн хэмждэг. Иймээс тайлант үеийн ашиг, алдагдал нь хөрөнгө, өр төлбөрийг эзэмшиж байх явцад тухайн тайлант үед үүссэн үнийн шилжилт хөдөлгөөнийг тусгадаг бөгөөд уг хөрөнгийн борлуулалтын хувьд ашиг, алдагдал тайлагнахгүй. Хөрөнгийг нээлттэй, идэвхитэй, хэвийн зах зээлд арилждаг тохиолдолд уг зах зээлийн оршин байдал нь тайлангийн өдрөөр тухайн байгууллага зах зээлийн үнээр (түүнээс илүүгүй дүнгээр) борлуулах боломжтой гэсэн баталгаагаар хангадаг: иймээс хөрөнгийн борлуулалтаар ашиг хэрэгжих хүртэл уг үнэ цэнийн өөрчлөлтийн хүлээн зөвшөөрөлтийг хойшлуулах шаардлагагүй юм. Гэвч үйлчилгээ үзүүлэхэд ашигласан хөрөнгийг нээлттэй, идэвхитэй, хэвийн зах зээлд буюу ийм зах зээлтэй маш ойролцоо зах зээлд арилждаггүй тохиолдолд зах зээлийн үнийн өөрчлөлттэй холбоотой орлого болон зардлын хамааралтай байдал нь ихээхэн эргэлзээтэй болдог.

*Үйл ажиллагааны чадавхи*

7.33 Ирээдүйн тайлант үеүдэд үйлчилгээ үзүүлэхээр эзэмшиж буй хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийн талаархи мэдээлэл нь үйлчилгээ үзүүлэх буюу

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

нийлүүлэхдээ тухайн хөрөнгийг ашигласнаар байгууллагын олж болох үнэ цэнийг тусган харуулж байвал ач холбогдолтой байдаг. Гэвч гарах үнэ цэнэд үндэслэсэн зах зээлийн үнэ нь түүхэн өртгөөс мэдэгдэхүйц бага бол тухайн хөрөнгийн үйл ажиллагааны чадавхийн талаархи мэдээллээр хангахад уг зах зээлийн үнэ нь тэрхүү хөрөнгийн түүхэн өртгөөс хамаарал багатай байх магадлалтай юм. Ийм зах зээлийн үнэ нь орох үнэ цэнэд үндэслэсэн одоогийн хэмжүүрээс мөн хамаарал багатай байх магадлалтай байдаг.

*Санхүүгийн чадавхи*

- 7.34 Санхүүгийн чадавхийн үнэлгээ нь тухайн хөрөнгийн борлуулалтаас хүлээн авах дүнгийн талаархи мэдээллийг шаарддаг. Энэ мэдээллийг зах зээлийн үнэ цэнээр бүрдүүлдэг.

*Чанарын шинжүүдийг ашиглах*

- 7.35 Нээлттэй, идэвхитэй, хэвийн зах зээлээр тодорхойлсон үнэ цэнийг санхүүгийн тайлагналын зорилгоор шууд ашиглаж болох юм. Ийм мэдээлэл нь чанарын шинжүүдийг, өөрөөр хэлбэл хамааралтай, үнэн зөв илэрхийлэх, ойлгомжтой байх, зэрэгцүүлэгдэх ба шалгах боломжтой байх гэсэн шинжүүдийг хангадаг. Ийм зах зээлийн нөхцлийн хувьд орох ба гарах үнэ цэнүүд нь ижил буюу маш төсөөтэй гэж үзэж болно. Энэхүү мэдээллийг бэлтгэхэд хурдан, хялбар учраас мөн цаг хугацаандаа байх магадлалтай юм.
- 7.36 Зах зээлийн нотолгооны чанар буурч, ийм үнэ цэнийн тодорхойлолт нь тооцооллын арга зүйд тулгуурлахын хэрээр зах зээлийн үнэ цэнэ нь чанарын шинжүүдийг хангах хэмжээ багасах юм. Дээр дурдсанчлан, гарах үнэ цэнэд үндэслэсэн зах зээлийн үнэ нь үйлчилгээний өртөг болон үйл ажиллагааны чадавхийн үнэлгээнд бус, харин санхүүгийн чадавхийн үнэлгээтэй зөвхөн холбоотой байх магадлалтай юм.

**Орлуулалтын өртөг**

- 7.37 Орлуулалтын өртөг<sup>13</sup> гэдэг нь:

*Тухайн тайлангийн өдрөөр уг хөрөнгийн үйлчилгээний чадавхийг (үүн дотроо, байгууллага нь хөрөнгийн ашиглалтын хугацааны эцэст түүний данснаас хасалтаас хүлээн авах дүнг) орлуулахад тэрхүү байгууллагад шаардлагатай хамгийн хэмнэлттэй өртөг юм.*

---

<sup>13</sup> Уг нэр томъёоны бүтэн нэр нь “элэгдэл тооцсон хамгийн оновчтой орлуулалтын өртөг” бөгөөд тухайн хөрөнгийг өөрийг нь биш, харин түүнд агуулагдаж буй үйлчилгээний чадавхийн орлуулалт гэсэн утгыг илэрхийлнэ (7.41-р параграфыг үзнэ үү). Үзэл баримтлалд заасан, хэмнэлттэй гэсэн хэллэгийн хувьд “орлуулалтын өртөг”-ийг ашиглана.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

7.38 Дараах шалтгааны улмаас орлуулалтын өртөг нь зах зээлийн үнэ цэнээс ялгаатай байдаг. Үүнд:

- Улсын секторын хүрээнд, орох үнэ цэнэ нь тухайн хөрөнгийн үйлчилгээний чадавхийг орлуулах өртгийг тусгана гэсэн утгатай байдаг;
- Энэ нь хөрөнгийн үйлчилгээний чадавхийг орлуулахад зайлшгүй гарах бүх өртөг зардлыг агуулсан байдаг;
- Энэ нь байгууллагын тусгайлсан үнэ цэнэ, иймээс таагласан зах зээл дэх зонхилох төлөв байдлыг биш, харин тухайн байгууллагын эдийн засгийн байдлыг тусган илэрхийлдэг. Жишээлбэл; тээврийн хэрэгслийн орлуулалтын өртөг нь маш олон тооны тээврийн хэрэгслийг нэг ажил гүйлгээгээр ихэвчлэн худалдан авдаг байгууллагын хувьд арай бага байх бөгөөд тээврийн хэрэгслийг тус тусад нь худалдан авдаг байгууллагатай харьцуулахад хөнгөлөлттэй үнийн хэлцэл хийх боломжтой байдаг.

7.39 Байгууллага нь боломжит хамгийн хэмнэлттэй арга хэрэгслээр хөрөнгийг ихэвчлэн худалдан авдаг учраас орлуулалтын өртөг нь тухайн байгууллагын ерөнхийдөө баримталдаг худалдан авалтын буюу барьж байгуулах процессыг тусгадаг. Орлуулалтын өртөг нь гал түймэр гэх мэт урьдчилан харах боломжгүй зарим үйл явдлын үр дүнд яаралтай шаардлага үүссэнээр зарцуулж болох өртөг зардлыг биш, харин хэвийн үйл ажиллагааны явц дахь үйлчилгээний чадавхийн орлуулалтыг тусган илэрхийлдэг.

7.40 Орлуулалтын өртөг нь хөрөнгийн үйлчилгээний чадавхийг орлуулах өртөг зардал юм. Орлуулалтын өртөг нь хамгийн оновчтой хандлагыг баримталдаг бөгөөд ижил төсөөтэй хөрөнгийг олж эзэмших өртөг болох дахин үйлдвэрлэлийн өртгөөс ялгаатай байдаг.<sup>14</sup> Хэдийгээр олон тохиолдолд үйлчилгээний чадавхийн хамгийн хэмнэлттэй орлуулалт нь түүний хянаж буй хөрөнгөтэй ижил төсөөтэй хөрөнгийн худалдан авалт байх боловч хэрэв сонголтот хувилбар нь уг үйлчилгээний чадавхийг арай хямдаар бүрдүүлэхээр байвал орлуулалтын өртөг нь тэрхүү сонголтот хувилбар хөрөнгөнд үндэслэнэ. Иймээс санхүүгийн тайлагналын зорилгоор, одоо байгаа болон орлуулах хөрөнгийн хоорондох үйлчилгээний чадавхийн ялгаатай байдлыг тусгах шаардлагатай байдаг.

7.41 Тохиромжтой үйлчилгээний чадавхи гэдэг нь тухайн байгууллагын ашиглаж байгаа буюу ашиглахаар хүлээж буй чадавхи бөгөөд болзошгүй нөхцлийг зохицуулах хангалттай үйлчилгээний чадавхийг бүрдүүлэх хэрэгээ шаардлагыг үүнд харгалзсан байна. Иймээс хөрөнгийн орлуулалтын өртөг нь шаардлагатай үйлчилгээний чадавхийн бууралтыг тусгадаг. Жишээлбэл; байгууллага нь 500 сурагчийг сургах хүчин чадалтай сургуулийг өмчилдөг боловч түүнийг барьж байгуулсны дараах хүн ам зүйн

---

<sup>14</sup> Орлуулалтын өртөг нь дахин үйлдвэрлэлийн өртөгтэй тэнцэх тийм тохиолдол байж болох юм. Үйлчилгээний чадавхийг орлуулах хамгийн хэмнэлттэй арга зам нь тухайн хөрөнгийг дахин үйлдвэрлэх явдал бол ийм тохиолдол үүсдэг.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТой  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

шилжилт хөдөлгөөний улмаас 100 сурагчид зориулагдсан сургууль нь одоогийн болон ул үндэслэлтэйгээр урьдчилан харж болох ирээдүйн хэрэгцээ шаардлагад тохиромжтой байвал тухайн хөрөнгийн орлуулалтын өртөг нь 100 сурагчид зориулсан сургуулийн өртөг байна.

- 7.42 Зарим тохиолдолд хөрөнгөөс бий болох үнэ цэнэ нь түүний орлуулалтын өртгөөс их байдаг. Гэвч энэ нь тухайн тайлангийн өдрөөрх үйлчилгээний чадавхиас гадна ирээдүйн үйл ажиллагаанаас бий болох үр өгөөжийг тусгадаг тул хөрөнгийг тэрхүү үнэ цэнээр хэмжих нь тохиромжгүй юм. Тодорхойлолт ёсоор, байгууллага нь орлуулалтын өртгийг зарцуулснаар адилтгах үйлчилгээний чадавхийг бүрдүүлж чадах учраас орлуулалтын өртөг нь тухайн хөрөнгийн боломжит хамгийн өндөр үнэ цэнийг илэрхийлдэг.

*Үйлчилгээний өртөг*

- 7.43 Орлуулалтын өртөг нь үйлчилгээ үзүүлэх өртөг зардлын хувьд хамааралтай хэмжүүрийг бий болгодог. Хөрөнгийн ашиглан зарцуулалтын өртөг нь тэрхүү ашиглалтаар үүсэх үйлчилгээний чадавхи алдалтын дүнтэй тэнцүү байдаг. Тэрхүү дүн нь түүний орлуулалтын өртөг юм. Өөрөөр хэлбэл, байгууллага нь орлуулалтын өртөгтэй тэнцүү зарлагаар тухайн хөрөнгийн ашиглан зарцуулалтын яг өмнөх түүний төлөв байдлыг сэргээн бүрдүүлэх боломжтой байдаг.

- 7.44 Орлуулалтын өртөгт үндэслэдэг тохиолдолд үйлчилгээний өртгийг одоогийн нөхцлөөр тайлагнана. Иймээс ашиглан зарцуулсан хөрөнгийн дүнг түүний олж эзэмших үеийн түүхэн өртгөөр биш, харин тухайн хөрөнгийг ашиглан зарцуулах үеийн үнэ цэнээр бүртгэнэ. Ингэснээр үйлчилгээний өртөг ба ерөнхийдөө, тухайн тайлант үеийн ажил гүйлгээ болох бөгөөд одоогийн үнээр хэмждэг татварын дүн болон уг тайлант үед хүлээн авсан бусад орлого хооронд зэрэгцүүлэлт хийх, түүнчлэн нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай ашигласан эсэхийг үнэлэх бодит суурийг бүрдүүлнэ. Мөн түүнчлэн, хөрөнгийн үнэ цэнүүдэд худалдан авалтын өөр өөр өдрүүд нөлөөлөхгүй учраас тухайн нэг сууриар тайлагнадаг бусад байгууллагуудтай зэрэгцүүлэх ач холбогдолтой суурийг үүгээр бас бий болгодог. Үүнээс гадна, үнэ нь янз бүр байсан өнгөрсөн үед гарсан өртөг зардалтай харьцуулахад ирээдүйн өртөг нь одоогийн өртөгтэй ижил байх магадлалтай учраас ирээдүйд үйлчилгээ үзүүлэх өртөг болон нөөцийн ирээдүйн хэрэгцээ шаардлагыг үнэлэхэд энэ нь мөн ач холбогдолтой суурь болдог (7.48-р параграфыг бас үзнэ үү).

*Үйл ажиллагааны чадавхи*

- 7.45 Орлуулалтын өртөг нь хөрөнгийн одоогийн үнэ цэнэ болон тухайн байгууллага дахь түүний үйлчилгээний чадавхид голлон чиглэдэг учраас ирээдүйн тайлант үеүдэд үйлчилгээ үзүүлэхэд бэлэн боломжтой байгаа нөөцийн ач холбогдолтой хэмжүүрийг үндсэндээ бүрдүүлдэг.

*Санхүүгийн чадавхи*

- 7.46 Орлуулалтын өртөг нь хөрөнгийн борлуулалтаар хүлээн авах дүнгийн талаархи мэдээллээр хангадаггүй. Иймээс энэ нь санхүүгийн чадавхийн үнэлгээнд туслалцаа үзүүлдэггүй.

*Чанарын шинжүүдийг ашиглах*

- 7.47 Дээр дурдсанчлан, орлуулалтын өртөг нь үйлчилгээний өртөг болон үйл ажиллагааны чадавхийн үнэлгээнд хамааралтай байдаг. Энэ нь санхүүгийн чадавхийн үнэлгээнд хамааралгүй юм. Зарим тохиолдолд орлуулалтын өртгийн тооцоолол нь нарийн цогц бөгөөд шүүн тунгаалт хийхийг шаарддаг. Эдгээр хүчин зүйлс нь орлуулалтын өртгийн үнэн зөв илэрхийллийг бууруулж болох юм. Ийм нөхцөл байдалд орлуулалтын өртгөөр бэлтгэсэн мэдээллийн цаг хугацаандаа байх, зэрэгцүүлэгдэх боломжтой байх, шалгах боломжтой байх шинжүүдэд нөлөөлөх бөгөөд орлуулалтын өртөг нь бусад зарим хувилбараас илүү өртөг зардалтай байж болно. Орлуулалтын өртгийн мэдээлэл нь тухайлбал, шаардлагатай үйлчилгээний чадавхийн бууралтыг тусгадаг тохиолдолд түүнийг ойлгоход энгийн хялбар биш байж болно (7.41-р параграфыг үзнэ үү).
- 7.48 Адилтгах үйлчилгээний чадавхийг бүрдүүлдэг хөрөнгүүдийг хэзээ худалдан авснаас үл хамааран ижил төсөөтэй дүнгүүдээр бүртгэдэг учраас орлуулалтын өртгийн мэдээллийг тухайн байгууллагын хүрээнд зэрэгцүүлэх боломжтой байдаг. Орлуулалтын өртөг нь тухайн байгууллагад бэлэн боломжтой байгаа орлуулалтын нөхцлийг тусган илэрхийлдэг байгууллагын тусгайлсан хэмжүүр учраас зарчмын хувьд, янз бүрийн байгууллагууд нь ижил төсөөтэй хөрөнгүүдийг өөр өөр дүнгээр тайлагнаж болох юм. Орлуулалт хийх боломж нь улсын секторын янз бүрийн байгууллагуудын хувьд ижил буюу төсөөтэй байж болно. Харин боломжууд нь өөр өөр байх тохиолдолд хөрөнгийг арай хямдаар олж эзэмших боломжтой байгууллагын эдийн засгийн давуу талыг үнэн зөв илэрхийлэх үүднээс хөрөнгийн үнэ цэнийг болон үйлчилгээний өртгийг арай бага тусгах замаар санхүүгийн тайланд тайлагнадаг.

**Борлуулалтын цэвэр үнэ**

- 7.49 Борлуулалтын цэвэр үнэ гэдэг нь:

*Хөрөнгийн борлуулалтаас уг борлуулалтын өртгийг хассаны дараа тухайн байгууллагын олж авах дүн юм.*

- 7.50 Борлуулалтын цэвэр үнэ нь нээлттэй, идэвхитэй, хэвийн зах зээл байх буюу ийм зах зээл дэх үнийн тооцоолол хийхийг шаарддаггүй бөгөөд тухайн байгууллагын борлуулалтын өртгийг хамруулдаг учраас зах зээлийн үнэ цэнээс өөр юм. Иймээс борлуулалтын цэвэр үнэ нь борлуулалтын хязгаарлалтыг тусгадаг. Энэ нь байгууллагын тусгайлсан хэмжүүр юм.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

- 7.51 Хөрөнгийг борлуулалтын цэвэр үнээр хэмжихийн боломжит ач холбогдол нь тухайн байгууллагад уг хөрөнгө түүний борлуулалтаар олж авч болох дүнгээс багагүй үнэ цэнэтэй байх явдал юм. Гэвч байгууллага нь хөрөнгийг өөр арга замаар ашигласнаар, жишээлбэл; үйлчилгээ үзүүлэхдээ тухайн хөрөнгийг ашигласнаар өөрийн нөөцийг илүү үр ашигтайгаар зарцуулах боломжтой байвал уг үнэ нь хэмжилтийн суурь болоход тохиромжгүй байдаг.
- 7.52 Иймээс тухайн байгууллагын хувьд нөөцийг зарцуулах хамгийн үр ашигтай арга нь хөрөнгийг борлуулах явдал байх тохиолдолд борлуулалтын цэвэр үнэ нь ач холбогдолтой байдаг. Тухайн хөрөнгө наад зах нь, борлуулалтын цэвэр үнэтэй адилтгах үнэ цэнэ бүхий үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөж бий болгох чадварыг бүрдүүлж чадахгүй тохиолдолд ийм нөхцөл байдал үүсдэг. Байгууллага нь зах зээлийн үнэ цэнээс бага үнээр хөрөнгийг борлуулах гэрээний үүрэг хүлээсэн тохиолдолд борлуулалтын цэвэр үнэ нь ач холбогдолтой мэдээллээр хангаж болох юм. Борлуулалтын цэвэр үнэ нь хөгжүүлэлтийн боломжийг илэрхийлэх тохиолдлууд байж болно.

*Үйлчилгээний өртөг*

- 7.53 Үйлчилгээ үзүүлэх өртгийг борлуулалтын цэвэр үнээр тооцох нь тохиромжгүй юм. Ийм хандлага нь тайлагнасан зардлын суурь болгон гарах үнэ цэнийг ашигладаг.

*Үйл ажиллагааны чадавхи*

- 7.54 Үйлчилгээ үзүүлэхэд ашиглах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийг борлуулалтын цэвэр үнээр илэрхийлэх нь үйл ажиллагааны чадавхийн үнэлгээнд ач холбогдолтой мэдээллээр хангадаггүй. Борлуулалтын цэвэр үнэ нь тухайн хөрөнгөөс олж авч болох үйлчилгээний чадавхийн үнэ цэнийг бус, харин түүний борлуулалтаар хүлээн авч болох дүнг харуулдаг.

*Санхүүгийн чадавхи*

- 7.55 Дээр дурдсанчлан, санхүүгийн чадавхийн үнэлгээ нь хөрөнгийн борлуулалтаар хүлээн авах дүнгийн талаархи мэдээллийг шаарддаг. Борлуулалтын цэвэр үнийг ашигласнаар ийм мэдээллийг бүрдүүлдэг. Гэвч ийм хэмжүүр нь үйлчилгээ үзүүлэхийн тулд түүнийг үргэлжлүүлэн ашигласнаар илүү үнэ цэнэтэй үйлчилгээний чадавхийг бүрдүүлж болох хөрөнгийн хувьд хамааралгүй юм.

*Чанарын шинжүүдийг ашиглах*

- 7.56 7.52-р параграфт дурдсанчлан, тухайн байгууллагын хувьд нөөцийг зарцуулах хамгийн үр ашигтай арга нь хөрөнгийг борлуулах явдал байх зөвхөн тийм тохиолдолд борлуулалтын цэвэр үнэ нь хамааралтай мэдээллээр хангадаг. Идэвхитэй зах зээл оршин байх тохиолдолд түүнийг лавлагаа болгосноор борлуулалтын цэвэр үнийн үнэлгээг хийж болно. Том хөрөнгүүдийн хувьд мэргэжлийн үнэлгээ хийлгэх боломжтой бөгөөд өртөг

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

зардлын хувьд хэмнэлттэй байж болох юм. Борлуулалтын цэвэр үнэ нь ойлгомжтой мэдээллээр ерөнхийдөө хангадаг.

- 7.57 Борлуулалтын цэвэр үнэ нь хамааралтай байх ихэнх тохиолдолд үнэн зөв илэрхийлэх, шалгах боломжтой байх, цаг хугацаандаа байх гэсэн чанарын шинжүүдийг хангадаг.

**Ашиглалтын үнэ цэнэ**

- 7.58 Ашиглалтын үнэ цэнэ гэдэг нь:

*Хөрөнгийг үргэлжлүүлэн ашиглавал түүний үлдэх үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөж бий болгох чадвараас тухайн байгууллагад орох, түүнчлэн хөрөнгийн ашиглалтын хугацааны эцэст түүний данснаас хасалтаас байгууллагын хүлээн авах цэвэр дүнгийн өнөөгийн үнэ цэнэ юм.*

*Ашиглалтын үнэ цэнийн тохиромжтой байдал*

- 7.59 Ашиглалтын үнэ цэнэ нь хөрөнгийн ажиллагаагаар дамжуулан тухайн хөрөнгөөс болон ашиглалтын хугацааны эцэс дэх түүний данснаас хасалтаас олж болох дүнг илэрхийлдэг байгууллагын тусгайлсан үнэ цэнэ юм. Дээрх 7.42-р параграфт дурдсанчлан, хөрөнгөөс бий болох үнэ цэнэ нь түүний орлуулалтын өртгөөс ямагт их байх бөгөөд мөн түүхэн өртгөөс ихэвчлэн их байдаг. Ийм тохиолдолд хөрөнгийг түүний ашиглалтын үнэ цэнээр тайлагнах нь тодорхойлолт ёсоор ач холбогдол багатай бөгөөд байгууллага нь адилтгах үйлчилгээний чадавхийг орлуулалтын өртгөөр бүрдүүлж чадах юм.
- 7.60 Борлуулалтын цэвэр үнэ нь ашиглалтын үнэ цэнээс их байх тохиолдолд нөөцийг зарцуулах хамгийн үр ашигтай арга нь түүнийг үргэлжлүүлэн ашиглах бус, харин хөрөнгийг борлуулах явдал учраас ашиглалтын үнэ цэнэ нь мөн тохиромжтой хэмжилтийн суурь биш юм.
- 7.61 Иймээс ашиглалтын үнэ цэнэ нь орлуулалтын өртгөөс бага, харин борлуулалтын цэвэр үнээс их байх тохиолдолд түүнийг хэрэглэх нь тохиромжтой юм. Хөрөнгийг орлуулахад ашиггүй боловч түүний үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөж бий болгох чадварын үнэ цэнэ нь борлуулалтын цэвэр үнээс их байх үед ийм тохиолдол үүсдэг. Ийм нөхцөл байдалд ашиглалтын үнэ цэнэ нь тухайн байгууллага дахь уг хөрөнгийн үнэ цэнийг илэрхийлдэг.
- 7.62 Хөрөнгө буюу хөрөнгүүдийн бүлгийн нөхөгдөх дүнг тодорхойлохдоо ашиглалтын үнэ цэнийг ашигладаг учраас энэ нь зарим үнэ цэнийн бууралтын үнэлгээний хувьд тохиромжтой хэмжилтийн суурь болдог.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

*Үйлчилгээний өртөг, Үйл ажиллагааны чадавхи, Санхүүгийн чадавхи*

7.63 Ашиглалтын үнэ цэнийн боломжит нарийн цогц байдал<sup>15</sup>, түүний хязгаарлагдмал хэрэглээ, түүнчлэн мөнгө бий болгодоггүй хөрөнгийн улсын секторын хүрээн дэх үйл ажиллагаанд орлох зүйл болгон орлуулалтын өртгийг ашигладаг зэргийг харгалзан үзвэл, ашиглалтын үнэ цэнэ нь үйлчилгээний өртгийг тодорхойлоход ерөнхийдөө тохиромжгүй байдаг. Ашиглалтын үнэ цэнэ нь үйл ажиллагааны чадавхийн үнэлгээнд ач холбогдол багатай, харин орлуулахад ашиггүй боловч тэдгээрийн ашиглалтын үнэ цэнэ нь борлуулалтын цэвэр үнээс их байх олон тооны хөрөнгө бүхий байгууллагын нийтлэг нөхцөл байдалд ашиглалтын үнэ цэнэ зөвхөн ач холбогдолтой байх магадлалтай юм. Жишээлбэл; байгууллага нь ирээдүйд үйлчилгээ үзүүлэлтээ зогсоох боловч хөрөнгийн нэн даруй борлуулалтын орлого нь тухайн хөрөнгөнд агуулагдаж буй үйлчилгээний чадавхиас бага бол ийм тохиолдол үүсэж болно. Ашиглалтын үнэ цэнэ нь тухайн хөрөнгийн борлуулалтаас байгууллагын хүлээн авах цэвэр дүнгийн тооцооллыг агуулсан байдаг. Гэвч ашиглалтын үнэ цэнийн хязгаарлагдмал хэрэглээ нь санхүүгийн чадавхийн үнэлгээн дэх түүний хамааралтай байдлыг бууруулдаг.

*Чанарын шинжүүдийг ашиглах*

- 7.64 Ашиглалтын үнэ цэнийг зарим үнэ цэнийн бууралтын үнэлгээнд ашиглаж болох боловч санхүүгийн тайлагналын зорилтууд дахь түүний хамааралтай байдал нь 7.61-р параграфт заасан, нөхцөл байдлаар хязгаарлагддаг.
- 7.65 Бусад чанарын шинжүүдийг ашиглалтын үнэ цэнэ ханган биелүүлэх хэмжээ нь түүнийг хэрхэн тодорхойлж байгаагаас хамаардаг. Зарим тохиолдолд хөрөнгийг үргэлжлүүлэн ашиглана гэж үзээд түүнээс тухайн байгууллагын олох үнэ цэнийг тооцоолсноор уг хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг тодорхойлдог. Энэ нь тухайн хөрөнгөтэй холбоотой ирээдүйн мөнгөн орлогын гүйлгээ, эсвэл уг хөрөнгийн хяналтаар дамжуулан байгууллагад бий болох өртөг зардлын хэмнэлтэнд үндэслэж болох юм. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ, түүнчлэн мөнгөн гүйлгээний дүн ба цаг хугацаанд өөрчлөлт орох эрсдлийг ерөнхийдөө, ашиглалтын үнэ цэнийн тооцооллод харгалзан үздэг.
- 7.66 Ашиглалтын үнэ цэнийн тооцоолол нь нарийн цогц байж болно. Мөнгө бий болгогч үйл ажиллагаанд ашигладаг хөрөнгө нь ихэвчлэн бусад хөрөнгийн хамтаар мөнгөн гүйлгээг бий болгодог. Ийм тохиолдолд хөрөнгүүдийн бүлгийн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийг зөвхөн тооцоолж, дараа нь бие даасан хөрөнгүүдэд хуваарилалт хийснээр ашиглалтын үнэ цэнийг тооцоолж болно.
- 7.67 Улсын секторын хувьд, ихэнх хөрөнгийг арилжааны өгөөж бий болгох биш, харин үйлчилгээ үзүүлэхэд хувь нэмэр оруулах үндсэн зорилготойгоор эзэмшдэг: ийм хөрөнгийг “мөнгө бий болгодоггүй хөрөнгө” гэж нэрлэдэг.

---

<sup>15</sup> Доорх 7.66-р параграфыг үзнэ үү.



## УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Ашиглалтын үнэ цэнэ нь хүлээгдэж буй мөнгөн гүйлгээнээс ихэвчлэн үүсдэг тул ийм нөхцөлд түүнийг ашиглахад төвөгтэй байдаг. Хүлээгдэж буй мөнгөн гүйлгээнд үндэслэсэн ашиглалтын үнэ цэнэ нь тухайн байгууллага дахь уг хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийн үнэн зөв илэрхийлэл болохгүй учраас ашиглалтын үнэ цэнийг ингэж тооцоолох нь тохиромжгүй байж болох юм. Иймээс санхүүгийн тайлагналын зорилгоор орлох зүйл болгон орлуулалтын өртгийг ашиглах шаардлагатай байдаг.

- 7.68 Ашиглалтын үнэ цэнийг тодорхойлох арга нь олон тохиолдолд түүний үнэн зөв илэрхийллийг бууруулдаг. Энэ нь мөн ашиглалтын үнэ цэнэд үндэслэн бэлтгэсэн мэдээллийн цаг хугацаандаа байх, зэрэгцүүлэгдэх боломжтой байх, ойлгомжтой байх, шалгах боломжтой байх чанарын шинжид нөлөөлж болох юм.

### Өр төлбөрийн хэмжилтийн сууриуд

- 7.69 Энэ хэсэгт өр төлбөрийн хэмжилтийн сууриудыг авч хэлэлцэнэ. Хөрөнгийн талаархи хэсэгт авч үзсэн бүх хэлэлцүүлгийг энд дахин давтахгүй. Үүнд дараах хэмжилтийн сууриудыг харгалзан үздэг:

- Түүхэн өртөг;
- Гүйцэтгэлийн өртөг;
- Зах зээлийн үнэ цэнэ;
- Чөлөөлөгдөх өртөг;
- Үүрэг хариуцсаны үнэ.

### Түүхэн өртөг

- 7.70 Өр төлбөрийн хувьд түүхэн өртөг гэдэг нь:

*Өр төлбөрийг хариуцахын тулд хүлээн авсан төлбөр, энэ нь өр төлбөр үүсэх үед хүлээн авсан мөнгө буюу мөнгөтэй адилтгах хөрөнгө болон бусад зүйлийн бодит үнэ цэнэ юм.*

- 7.71 Түүхэн өртгийн загварын дагуу хүүний хуримтлуулалт, хөнгөлөлтийн нэмэгдүүлэлт буюу урамшууллын хорогдуулга гэх мэт хүчин зүйлсийг тусгахын тулд анхны хэмжүүрийг тохируулж болох юм.

- 7.72 Өр төлбөрийн цаг хугацааны үнэ цэнэ материаллаг, тухайлбал; төлбөрийг барагдуулах шаардлагатай болохоос өмнө мэдэгдэхүйц урт хугацаатай тохиолдолд энэ нь өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөх үед хүлээн авсан дүнгийн үнэ цэнийг илэрхийлэхийн тулд уг ирээдүйн төлбөрийн дүнг дискаунтчилдаг. Шаардлагатай төлбөрийг төлөх үеийн дүнгээр тухайн өр төлбөрийг бүртгэхийн тулд уг ирээдүйн төлбөрийн дүн ба өр төлбөрийн өнөөгийн үнэ цэнийн хоорондох зөрүүг тэрхүү өр төлбөрийн хугацааны туршид хорогдуулдаг.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТой  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

7.73 Өр төлбөрийн хувьд түүхэн өртгийн суурийг ашиглахын давуу ба сул тал нь түүнийг хөрөнгөнд хэрэглэхэд гардаг давуу болон сул талтай ижил төсөөтэй байдаг. Өр төлбөрийг тогтоосон нөхцлөөр барагдуулах магадлалтай тохиолдолд түүхэн өртөг нь тохиромжтой байдаг. Гэвч зөрчлийн төлбөр буюу иргэний хохирлыг барагдуулах өр төлбөр гэх мэт ажил гүйлгээнээс үүсээгүй өр төлбөрийн хувьд түүхэн өртгийг хэрэглэж болохгүй юм. Тухайн байгууллагын нөөцийн эсрэг гаргасан нэхэмжлэлийн үнэн зөв илэрхийллээр хангахгүй учраас арилжааны бус ажил гүйлгээгээр өр төлбөр үүссэн тохиолдолд энэ нь мөн холбогдох мэдээллээр хангах магадлал багатай байдаг. Тогтоосон тэтгэвэр, тэтгэмжийн өр төлбөртэй холбоотой гэх мэт дүн нь хувьсан өөрчлөгдөж болох өр төлбөрийн хувьд түүхэн өртгийг ашиглахад мөн төвөгтэй байдаг.

### Гүйцэтгэлийн өртөг

7.74 Гүйцэтгэлийн өртөг гэдэг нь:

*Өртөг зардал хамгийн бага байхаар гүйцэтгээнэ гэж төсөөлөхөд уг өр төлбөрөөр илэрхийлэгдэж буй үүргийн гүйцэтгэлийг хангахын тулд байгууллагын зарцуулах өртөг зардал юм.*

7.75 Гүйцэтгэлийн өртөг нь ирээдүйн тодорхой бус үйл явдлуудаас хамаардаг тохиолдолд уг гүйцэтгэлийн тооцоолсон өртөгт боломжит бүх үр дагавруудыг харгалзах бөгөөд аль нэг тал руу хэлбийгээгүй байдлаар тэдгээр боломжит бүх үр дагаврыг тусгахыг эрмэлздэг.

7.76 Гүйцэтгэл нь ажил хийхийг шаарддаг, тухайлбал; өр төлбөр нь байгаль орчны хохирлыг сэргээн засварлах явдал байх тохиолдолд холбогдох өртөг нь тухайн байгууллагын зарцуулах өртөг зардал байна. Энэ нь уг сэргээн засварлах ажлыг байгууллага өөрөө хийснээр эсвэл тэрхүү ажлыг гүйцэтгүүлэхээр гаднын талтай гэрээлсэн өртөг зардал байж болно. Гэвч гүйцэтгэгчийг хөлслөн ажиллуулах нь тухайн үүргийг биелүүлэх хамгийн бага өртөг зардалтай арга зам байх зөвхөн тийм тохиолдолд гаднын талтай гэрээлэх өртөг зардал нь хамааралтай байна.

7.77 Байгууллага өөрөө ажлыг гүйцэтгэх тохиолдолд тухайн гүйцэтгэлийн өртөг нь ямар нэг ашгийг агуулаагүй байдаг. Яагаад гэвэл, ийм аливаа ашиг нь уг байгууллагын нөөцийн ашиглалтыг илэрхийлдэггүй. Гүйцэтгэлийн дүн нь гүйцэтгэгчийг хөлслөн ажиллуулах өртөг зардалд үндэслэдэг тохиолдолд тэрхүү гүйцэтгэгчийн шаардах нийт дүн нь уг байгууллагын нөөцөд гаргах нэхэмжлэл байх учраас тухайн дүн нь гүйцэтгэгчийн шаардах ашгийг шууд бусаар агуулсан байдаг. Энэ нь орлуулалтын өртөгт бэлтгэн нийлүүлэгчийн шаардах ашгийг багтаах боловч байгууллага өөрөө барьж байгуулах замаар орлуулалт хийх хөрөнгийн орлуулалтын өртөгт ашиг тусгадаггүй, хөрөнгийн хувьд хэрэглэдэг хандлагатай нийцэж байна.

7.78 Гүйцэтгэлийг хугацаа сунган гүйцэтгэдэггүй тохиолдолд тухайн тайлангийн өдрөөрх өр төлбөрийн үнэ цэнийг тусгахын тулд мөнгөн гүйлгээг дискаунтчилах шаардлагатай байдаг.

7.79 Доор дурдсанаас бусад тохиолдолд гүйцэтгэлийн өртөг нь өр төлбөрийн хэмжилтэнд ерөнхийдөө хамааралтай байдаг:

- Байгууллага нь гүйцэтгэлийн өртгөөс бага дүнгээр уг үүргээс чөлөөлөгдөж чадах тохиолдолд тэрхүү чөлөөлөгдөх өртөг зардал нь тухайн өр төлбөрийн одоогийн дарамтын хувьд илүү хамааралтай хэмжүүр болдог. Хөрөнгийн хувьд борлуулалтын цэвэр үнэ нь ашиглалтын үнэ цэнээс өндөр бол илүү хамааралтай хэмжүүр болдогтой энэ нь ижил утгатай юм;
- Төлбөрийг хариуцах өр төлбөрийн хувьд, хэрэв үүрэг хариуцсаны үнэ (7.87-7.91-р параграфыг үзнэ үү) нь гүйцэтгэлийн өртөг ба чөлөөлөгдөх өртгийн аль алианаас өндөр бол илүү хамааралтай хэмжүүр болно.

### **Зах зээлийн үнэ цэнэ**

7.80 Өр төлбөрийн хувьд зах зээлийн үнэ цэнэ гэдэг нь:

*Зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хоорондох харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр өр төлбөрийг барагдуулж болох дүн юм.*

7.81 Өр төлбөрийн хувьд зах зээлийн үнэ цэнийн давуу ба сул тал нь хөрөнгийн хувьд үүсдэг давуу болон сул талтай ижил байна. Жишээлбэл; өр төлбөр нь нээлттэй, идэвхитэй, хэвийн зах зээл дэх тохиролцсон хүүний хувь, үнийн буюу ханшийн индексийн өөрчлөлтөнд өртөг тохиолдолд ийм хэмжилт тохиромжтой байж болно. Гэвч өр төлбөрийг шилжүүлэх чадвар боломж хязгаарлагдмал ба ийм шилжүүлгийг хийж болох эсэх нөхцөл нь тодорхойгүй тохиолдолд хэдийгээр зах зээлийн үнэ цэнэ оршин байж болох боловч түүнийг хэрэглэх боломж ихээхэн бага байдаг. Ялангуяа, арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн өр төлбөрт хамаарах нээлттэй, идэвхитэй, хэвийн зах зээл оршин байх магадлал багатай учраас уг өр төлбөрийн хувьд ийм тохиолдол гардаг.

### **Чөлөөлөгдөх өртөг**

7.82 “Чөлөөлөгдөх өртөг” нь хөрөнгийн хувьд хэрэглэдэг “борлуулалтын цэвэр үнэ” гэдэгтэй ижил ойлголт ухагдахууныг илэрхийлэхийн тулд өр төлбөрийн хувьд ашигладаг нэр томъёо юм. Чөлөөлөгдөх өртөг нь үүргээс нэн даруй чөлөөлөгдөх дүнг илэрхийлдэг. Чөлөөлөгдөх өртөг нь зээлдүүлэгчийн нэхэмжлэлийг барагдуулахад түүний зөвшөөрөх дүн эсвэл зээлдэгчээс өр төлбөрийг шилжүүлэхэд гуравдагч талын зөвшөөрөх дүн байдаг. Өр төлбөрөөс чөлөөлөх нэгээс олон арга зам байх тохиолдолд хамгийн бага дүнтэй нь чөлөөлөх өртөг байна. Хөрөнгийг ашиглах худалдан авагчид борлуулалт хийснээр арай өндөр үнэ олж авч чадахаар бол хөрөнгийг үлдэгдэл өртгөөр борлуулснаар хүлээн авах дүнд борлуулалтын цэвэр үнэ нөлөөлөхгүй байх хөрөнгийн хувьд хэрэглэдэг арга хандлагатай энэ нь нийцэх юм.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

- 7.83 Зарим өр төлбөрийн хувьд, ялангуяа улсын секторт өр төлбөрийг шилжүүлэх практик боломжгүй бөгөөд иймээс чөлөөлөх өртөг нь өөрийн нэхэмжлэлийг барагдуулахад зээлдүүлэгчийн хүлээн зөвшөөрөх дүн байна. Зээлдүүлэгчтэй байгуулсан гэрээнд үүнийг тусгайлан заасан, жишээлбэл; цуцлах тусгай заалтыг гэрээнд тусган оруулсан бол энэхүү дүн тодорхой байдаг.
- 7.84 Зарим тохиолдолд өр төлбөрийг шилжүүлж болох үнийн талаар нотолгоо байж болох юм. Жишээлбэл; тэтгэврийн зарим өр төлбөрийн тохиолдол. Тухайн байгууллагын үүргийг гүйцэтгэх буюу өр төлбөрөөс үүсэх бүх өртөг зардлыг хариуцахаар нөгөө талтай байгуулсан гэрээнээс өр төлбөрийн шилжүүлэлтийг ялган зааглаж болох юм. Шилжүүлэх өр төлбөрийн хувьд тухайн байгууллагын эсрэг гаргах зээлдүүлэгчийн бүх эрхийг дуусгавар болгох шаардлагатай байдаг. Хэрэв хэлцэл нь ийм үр дүнд хүрэхгүй бол тухайн өр төлбөр нь уг байгууллагын өр төлбөр хэвээр үлдэнэ.
- 7.85 Чөлөөлөгдөх өртөг нь өр төлбөрийг хэмжихэд тохиромжтой эсэхийг үнэлэхдээ, уг төсөөлсөн аргаар хийгдэх чөлөөлөлт нь байгууллагын нэр хүндэд хохирол учруулах гэх мэт тэрхүү чөлөөлөлтийг авсаны аливаа үр дагаврыг харгалзаж, тухайн байгууллагын практикт байж болох сонголт эсэхийг харгалзан үзэх шаардлагатай юм.
- 7.86 Тухайн байгууллагын хувьд хэрэглэх боломжтой, нөөцийг зарцуулах хамгийн үр ашигтай арга нь хөрөнгийг борлуулах явдал байх зөвхөн тийм тохиолдолд борлуулалтын цэвэр үнэ нь хамааралтай байдгийн адилаар нөөцийг зарцуулах хамгийн үр ашигтай арга нь үүргээс нэн даруй чөлөөлөгдөлт байх зөвхөн тийм тохиолдолд чөлөөлөгдөх өртөг нь хамааралтай байдаг. Ялангуяа, гүйцэтгэлийн өртөг нь чөлөөлөгдөх өртгөөс бага байх тохиолдолд хэдийгээр 7.84-р параграфт заасан, өр төлбөрийг шилжүүлэх аргын дагуу үүргээс чөлөөлөгдөх хэлцэл хийх боломжтой боловч гүйцэтгэлийн өртөг нь чөлөөлөгдөх өртгөөс илүү хамааралтай мэдээллээр хангадаг.

### **Үүрэг хариуцсаны үнэ**

- 7.87 “Үүрэг хариуцсаны үнэ” нь хөрөнгийн хувьд хэрэглэдэг орлуулалтын өртөгтэй ижил ойлголтыг илэрхийлэхийн тулд өр төлбөрийн хувьд хэрэглэдэг нэр томъёо юм. Орлуулалтын өртөг нь хөрөнгийг олж эзэмшихийн тулд байгууллагын ул үндэслэлтэйгээр төлөх дүнг илэрхийлдэгийн адилаар үүрэг хариуцсаны үнэ нь одоо байгаа өр төлбөрийг хариуцсаны хариуд байгууллагын ул үндэслэлтэйгээр хүлээн зөвшөөрөхөд бэлэн байгаа дүн юм. Харилцан хамааралгүй талуудын нөхцлөөр хийсэн арилжааны ажил гүйлгээ нь үүрэг хариуцсаны үнийн талаархи нотолгоогоор хангадаг – харин арилжааны бус ажил гүйлгээний хувьд ийм нотолгоогоор хангадаггүй.
- 7.88 Ашиг олох санаа зорилготойгоор гүйцэтгэсэн үйл ажиллагааны хувьд өр төлбөрийг хариуцуулахын тулд түүнд төлөх дүн нь гүйцэтгэлийн өртөг болон чөлөөлөлтийн өртгөөс, өөрөөр хэлбэл барагдуулалтын дүнгээс илүү

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

байх зөвхөн тийм тохиолдолд байгууллага нь өр төлбөрийг хариуцна. Байгууллага нь үүрэг хариуцах үнийг хүлээн зөвшөөрснөөр түүний зээлдүүлэгчийн хувьд үүрэг хүлээнэ.

- 7.89 Арилжааны ажил гүйлгээгээр өр төлбөр анх үүсэх үед үүрэг хариуцсаны үнэ нь уг өр төлбөрийг хариуцсанаар байгууллагын хүлээн зөвшөөрсөн дүнг илэрхийлдэг - иймээс үүрэг хариуцсаны үнэ нь ижил төсөөтэй өр төлбөрийг хариуцсанаар тухайн байгууллагын ул үндэслэлтэйгээр хүлээн зөвшөөрөх үнэ гэж үзэх нь ихэвчлэн үндэслэлтэй байдаг. Өрсөлдөөнт байдал нь ингэж өр төлбөр хариуцахыг зөвшөөрөх боловч арай бага үнээр хүлээн зөвшөөрөхгүй байж болох тул арай өндөр үнэ тогтоодог. Орлуулалтын өртөг нь одоогийн үнэ цэнэ байдгийн адилаар, үүрэг хариуцсаны үнэ нь онолын хувьд мөн одоогийн үнэ цэнэ байна. Гэвч үүрэг хариуцсаны үнээр бүртгэсэн үүргийн үнийн өөрчлөлтийг тусгахад практикт төвөгтэй байдаг.
- 7.90 Үүрэг хариуцсаны үнээр тухайн гүйцэтгэлийн үүргийг бүртгэсний үр дүнд уг үүргийг хариуцан хүлээн авах үед ашиг тайлагнахгүй. Өр төлбөрийн биелүүлэлтээс үүссэн орлого ба түүний барагдуулалтын өртгийн хоорондох зөрүү тул ашиг, алдагдлыг тухайн үүргийг биелүүлсэн (эсвэл чөлөөлөгдсөн) тохиолдолд санхүүгийн тайланд тайлагнадаг.
- 7.91 Байгууллага нь үүрэг хариуцсаны үнээс илүү дүн бүхий боломжит үүрэгтэй байж болох юм. Хэрэв байгууллага нь гэрээнээс чөлөөлөгдөхийг хүсвэл уг гэрээний оролцогч нөгөө тал нь учрах хохирлын нөхөн төлбөр, түүнчлэн төлсөн аливаа дүнг буцааж өгөхийг шаардаж болно. Гэвч байгууллага нь гүйцэтгэл хийснээр үүргийг барагдуулж болохоор байвал ийм нэмэлт үүргээс зайлсхийж болох ба үүрэг хариуцсаны үнээс илүүгүй дүнгээр уг үүргийг тайлагнах нь үнэн зөв илэрхийлэл болох юм. Энэ нь орлуулалтын өртгөөс илүү үр өгөөж бий болгох хөрөнгийн нөхцөл байдалтай төсөөтэй байна. 7.42-р параграфт тайлбарласанчлан, ийм нөхцөл байдалд ашиглалтын үнэ цэнэ биш, харин орлуулалтын өртөг нь хамгийн их хамааралтай хэмжилтийн суурь болдог.

## Дүгнэлтийн үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь Онолын Үзэл Баримтлалыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### Онолын үзэл баримтлал дахь хэмжилтийн үүрэг

ДҮ7.1. Санхүүгийн тайланд зориулсан ирээдүйн стандарт тогтоох үйл ажиллагааны найдвартай ба ил тод, ойлгомжтой үндэслэлийг бүрдүүлэхийн тулд Онолын үзэл баримтлалын гол анхаарал хандуулах анхны зүйл нь санхүүгийн тайлангийн элементүүдийн хэмжилт байвал зохино гэж УСНББОУСЗ шийдвэрлэсэн. “Санхүүгийн Тайлан дахь Хөрөнгө, Өр Төлбөрийн Хэмжилт” гэсэн Зөвлөлдөх Баримт Бичиг (Зөвлөлдөх Баримт Бичиг)-т хариулт ирүүлсэн зарим цөөн хүмүүс нь энэхүү хандлагад эргэлзэж байсан бөгөөд УСНББОУСЗ нь энэхүү үе шатны цар хүрээг хязгаарлах уг анхны үндэслэлийг зөв гэж үзсэн ба түүнийг дахин баталгаажуулсан.

### Хэмжилтийн зорилт

ДҮ7.2. УСНББОУСЗ нь хэмжилтийн тусгай зорилтыг боловсруулж тодорхойлох хэрэгтэй эсэхийг авч үзсэн. Хэмжилтийн зорилт нь санхүүгийн тайлагналын зорилтууд болон чанарын шинжүүдийг нэмж гүйцээх бус, харин мөр зэрэгцэн оршиж болох учраас УСНББОУСЗ нь хэмжилтийн тусдаа зорилт шаардлагагүй гэсэн байр суурийг эхлээд баримталж байсан. Иймээс “Санхүүгийн Тайлан дахь Хөрөнгө, Өр Төлбөрийн Хэмжилт” гэсэн Зөвлөлдөх Баримт Бичиг (Зөвлөлдөх Баримт Бичиг) нь санхүүгийн тайлагналын зорилтууд болон чанарын шинжүүдэд нийцсэн хэмжилтийн суурийн сонголтонд хамааралтай хүчин зүйлсийг санал болгосон боловч хэмжилтийн зорилтыг тусган оруулаагүй.

ДҮ7.3. Энэхүү хандлагын дагуу, Онолын үзэл баримтлал нь бүх нөхцөл байдалд зориулсан хэмжилтийн нэг суурь (буюу сууриудын хослол) тодорхойлохыг эрмэлзээгүй гэдгийг Саналын Төсөлд илэрхийлсэн. Бүх нөхцөл байдалд ашиглах хэмжилтийн нэг суурийг санал болгох нь санхүүгийн тайланд тайлагнасан өөр өөр дүнгүүдийн хоорондох харилцан холбоог тодруулж өгнө, ялангуяа ач холбогдолтой нийт дүнг гаргахын тулд янз бүрийн хөрөнгө, өр төлбөрийн дүнгүүдийг нэгтгэн нийлүүлэх боломж бүрдүүлнэ гэж УСНББОУСЗ мэдэгдсэн. Гэвч санхүүгийн тайлан нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг хангах ба чанарын шинжүүдийг биелүүлэх хэмжээг хамгийн их болгох тийм хэмжилтийн нэг суурь байхгүй гэсэн байр суурийг УСНББОУСЗ илэрхийлсэн.

ДҮ7.4. Хэмжилтийн зорилтыг санхүүгийн тайлагналын зорилттой уялдуулан холбоогүй тийм Онолын үзэл баримтлал нь бүрэн бус, түүнчлэн санхүүгийн тайлагналын стандартуудын хооронд болон цаг хугацааны явцад хэмжилтийн талаар тууштай шийдвэр гаргах УСНББОУСЗ-ийн чадвар боломжийг хязгаарлана гэсэн үндэслэлээр хэмжилтийн зорилтыг санал болгосон Хувилбар Байр Суурийг уг Саналын Төсөлд тусган оруулсан. Мөн

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

түүнчлэн, хэмжилтийн зорилтгүй байх нь хөрөнгө, өр төлбөрийн ижил төсөөтэй ангиудыг хэмжих өөр өөр буюу тохиромжгүй хэмжилтийн сууриудыг ашиглах эрсдэлтэй гэдгийг энэхүү Хувилбар Байр Суурьт илэрхийлсэн. Хувилбар Байр Суурь нь дараах хэмжилтийн зорилтыг санал болгосон:

*Байгууллагын тайлагналын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд ач холбогдолтой тийм арга замаар уг байгууллагын санхүүгийн чадавхи, үйл ажиллагааны чадавхи болон үйлчилгээний өртгийг хамгийн үнэн зөв тусган илэрхийлэх тэдгээр хэмжилтийн шинжүүдийг сонгох.*

- ДҮ7.5. Саналын Төсөлд тусгасан хандлагыг ерөнхийдөө дэмждэг, хариулт өгсөн олон хүмүүс нь Хувилбар Байр Суурийг дэмжсэн. Онолын үзэл баримтлалын хэмжилтийн хандлага нь өндөр хүсэл эрмэлзэлтэй байх бөгөөд капиталын туйлын ойлголт ухагдахуунаар<sup>16</sup> илэрхийлэх хэмжилтийн нэг суурийг Онолын үзэл баримтлалд тодорхойлох хэрэгтэй гэсэн байр суурийг УСНББОУСЗ бас мэдэгдсэн. Үйл ажиллагааны хүчин чадлын ойлголт ухагдахуун нь хамааралтай бөгөөд үйлчилгээ үзүүлэх анхдагч зорилго бүхий улсын секторын байгууллагуудад зориулж түүнийг боловсруулж болно гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Гэвч ийм хэмжилтийн зорилтын мөрдөлт нь санхүүгийн байдлыг тайлагнахдаа үйл ажиллагааны чадавхийг илэрхийлэх үед түүхэн өртгийн хэмжилтээс одоогийн өртгийн хэмжилт давуутай гэсэн туйлын тодорхой мэдэгдлийг агуулсан байдаг. ДҮ7.15-ДҮ7.19-р параграфт авч хэлэлцсэн учир шалтгааны улмаас УСНББОУСЗ нь уг хэмжилтийн зорилтыг түүхэн өртгийн хэмжүүр ямагт хангах бөгөөд иймээс Онолын үзэл баримтлалд зохих ач холбогдол өгөх хэрэгтэй гэж үзсэн.
- ДҮ7.6. Хэмжилтийн сууриудын сонголтын талаархи стандартын түвшний шийдвэрүүдийг удирдамжаар хангахад хэмжилтийн зорилт шаардлагатай гэж үздэг хүмүүсийн үзэл бодол нь УСНББОУСЗ-д дараа нь нөлөө үзүүлсэн. Гэвч хөрөнгө, өр төлбөр нь байгууллагын санхүүгийн үр дүн, санхүүгийн байдалд янз бүрийн байдлаар хувь нэмрээ оруулдаг бөгөөд ийм үнэлгээ нь санхүүгийн чадавхи болон үйл ажиллагааны чадавхид тэдний оруулсан хувь нэмрийн хэмжээнд үндэслэвэл зохино гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Хэмжилтийн суурийг капиталын туйлын ойлголт ухагдахуунтай холбох нь хэмжилтийн сууриудын сонголтыг хэт хязгаарлаж болох юм гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Иймээс хэмжилтийн зорилтын мөрдөлт нь капиталын туйлын ойлголт ухагдахуунд үндэслэвэл зохино гэсэн байр суурийг УСНББОУСЗ үгүйсгэсэн бөгөөд улсын секторын стандарт тогтоолтонд хэмжилтийн холимог хандлага тохиромжтой гэсэн өөрийн байр суурийг дахин баталгаажуулсан.
- ДҮ7.7. Хувилбар Байр Суурьт санал болгосон хэмжилтийн зорилт нь тохиромжтой эсэхийг УСНББОУСЗ авч үзсэн. Уг санал болгосон хэмжилтийн зорилт нь одоогийн үнэ цэнийн хэмжилтэд хэт тулгуурласан байна гэж зарим хүмүүс

---

<sup>16</sup> Капиталын ийм ойлголт ухагдахуунд оруулсан мөнгөн капитал, одоогийн мөнгөтэй адилтгах хөрөнгө, үйл ажиллагааны хүчин чадал хамаардаг.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТой  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

шүүмжилсэн. Гэвч түүхэн өртөг ба одоогийн үнэ цэнийн хэмжүүрийн аль алиныг ашигласнаар үйлчилгээний өртгийг тодорхойлж болох учраас “үйлчилгээний өртөг” хэллэг нь түүхэн өртөгтэй хангалттай уялдаа холбоо бүрдүүлнэ гэсэн байр суурийг УСНББОУСЗ илэрхийлсэн. Иймээс УСНББОУСЗ нь Хувилбар Байр Суурьт санал болгосон зорилтонд зөвхөн багахан засвар өөрчлөлт оруулж, хэмжилтийн дараах зорилтыг баталсан:

*Байгууллагын тайлагналын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд ач холбогдолтой тийм арга замаар уг байгууллагын үйлчилгээний өртөг, үйл ажиллагааны чадавхи болон санхүүгийн чадавхийг хамгийн үнэн зөв тусган илэрхийлэх тэдгээр хэмжилтийн сууриудыг сонгох.*

ДҮ7.8. Өөр өөр хэмжилтийн сууриуд ашиглахын сул талуудыг дараах байдлаар хамгийн бага болгож болно гэдгийг УСНББОУСЗ бас тэмдэглэсэн:

- Эдийн засгийн нөхцөл байдал зөвтгөн батлах ба ингэснээр нөхцөл байдлууд ижил үед тухайн нэг сууриар хөрөнгө, өр төлбөрийг тайлагнасан гэдгийг ханган магадлах зөвхөн тийм тохиолдолд хэмжилтийн өөр өөр сууриудыг сонгох;
- Ашигласан хэмжилтийн суурь, түүнчлэн суурь тус бүрээр тайлагнасан дүнгүүд тодорхой гэдгийг ханган магадлахын тулд илт ойлгомжтой толилуулга болон тодруулга хийхийг шаардах.

**Анхны болон дараагийн хэмжилт**

ДҮ7.9. Хөрөнгө, өр төлбөрийг анхны удаа хүлээн зөвшөөрөх буюу анхны хэмжилт, мөн дараагийн тайлант үед санхүүгийн тайланд тайлагнах буюу дараагийн хэмжилтийн аль алины хувьд хэмжилтийн суурийг сонгох шаардлагатай. Анхны болон дараагийн хэмжилтэнд өөр өөр зарчим мөрдөхийг санал болгож болох тийм байдлаар нягтлан бодох бүртгэлийн зарим бодлогыг илэрхийлдэг. Жишээлбэл; хөрөнгийг эхлээд ажил гүйлгээний үнээр, дараа нь одоогийн үнэ цэнээр хүлээн зөвшөөрч болох юм. Иймээс анхны болон дараагийн хэмжилтийг Онолын үзэл баримтлалд тусад нь авч хэлэлцэх хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн.

ДҮ7.10. Анхны болон дараагийн хэмжилтийн хувьд өөр өөр сууриудыг тусгайлан зааж болох нэг шалтгаан бол дараагийн хэмжилтэнд ашиглах тухайн суурь нь анхны хэмжилтийн үед бэлэн боломжтой байдаггүй явдал юм. Хөрөнгийг заримдаа хувь нийлүүлдэг эсвэл хөнгөлөлттэй нөхцлөр буюу бусад мөнгөн бус хөрөнгийн солилцоогоор олгодог тохиолдолд энэ нь улсын секторт ихээхэн түгээмэл байдаг. Ийм тохиолдолд уг ажил гүйлгээний үнэ цэнэ мэдэгдэхгүй байж болох бөгөөд хэрэв хөрөнгийг дараагийн тайлант үед түүхэн өртөг буюу орлуулалтын өртөг гэх мэт орох үнэ цэнээр тайлагнадаг бол харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр худалдан авсан үед хөрөнгийг бүртгэх байсан тэрхүү дүнгийн орлуулагч болгон анхны хэмжилтийн хувьд өөр суурийг тусгайлан заах шаардлагатай байдаг. Ажил гүйлгээний үнэ мэдэгдэхгүй тохиолдолд аккруэл нягтлан бодох бүртгэлийг нэвтрүүлэхээс өмнө олж эзэмшсэн хөрөнгийн анхны хэмжилтийн хувьд орлуулагч мөн шаардлагатай байж болох юм.



УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Хэмжилтийн зорилт болон чанарын шинжүүдийг хангах орлуулагч ашиглах нь хэмжилтийн суурийн гажилт биш, харин түүний мөрдөлт юм.

ДҮ7.11. Анхны болон дараагийн хэмжилт илт өөр байх бас нэг шалтгаан нь хөрөнгийг одоогийн үнэ цэнээр тайлагнар үед үүсдэг бөгөөд уг ашиглах одоогийн хэмжилтийн суурийг тусгахын тулд тухайн ажил гүйлгээний үнийг төсөөлөн тооцдог. Ийм тохиолдолд уг хөрөнгийг ажил гүйлгээний үнээр анх хүлээн зөвшөөрнө гэдгийг тусгайлан заах нь тухайн бодлогын мөрдөлтөөр анхны хүлээн зөвшөөрөлтийн үед орлого ба зардал, өөрөөр хэлбэл “анхны өдөр”-ийн олз эсвэл гарз хүлээн зөвшөөрөхгүй гэдгийг тодорхой болгож өгдөг. Зарчмын хувьд, анхны болон дараагийн хүлээн зөвшөөрөлтөнд нэг ижил хэмжилтийн суурийг ашигладаг – ойлгоход туслалцаа үзүүлэхийн тулд тус бүрийн шаардлагуудыг өөр өөр байдлаар тусгайлан заадаг.

ДҮ7.12. Зарчмын хувьд, анхны болон дараагийн хэмжилтэнд ижил анхаарал хандуулна гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Иймээс энэ Бүлгийн хэлэлцүүлэг нь хоёр нөхцлийн аль алинд хамаарна.

**Орох ба гарах үнэ цэнэ: Ашиглалтын үнэ цэнэ**

ДҮ7.13. Орох эсвэл гарах хэтийн төлөвөөр хангадаг эсэхээс хамааран хэмжилтийн сууриудыг ангилж болно. 7.8-р параграфт авч хэлэлцсэнчлэн, орох үнэ цэнэ нь худалдан авалтын өртгийг, харин гарах үнэ цэнэ нь дараах хоёр зүйлийн аль нэгийг тусган илэрхийлдэг:

- Нэн даруй борлуулалтаас үүсэх эдийн засгийн үр өгөөж; эсвэл
- Тухайн хөрөнгийн ашиглалтаас болон дараагийн тайлант үед борлуулснаас үүсэх дүн.

Хэмжилтийн суурь нь орох эсвэл гарах үнэ цэнэ эсэхийг мэдэх нь хэмжилтийн зорилтыг хамгийн сайн хангах тэрхүү хэмжилтийн суурийг тодорхойлоход ач холбогдолтой байдаг гэж УСНББОУСЗ үздэг.

ДҮ7.14. Ашиглалтын үнэ цэнийг орох үнэ цэнэ эсвэл гарах үнэ цэнэ гэж ангилах хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ авч үзсэн. Мөнгө бий болгогч хөрөнгийн хувьд, ашиглалтын үнэ цэнэ нь бараа, үйлчилгээний борлуулалтаас хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг ашиглах, дискаунтчилсан мөнгөн гүйлгээний загварыг агуулсан байдаг. Мөнгө бий болгодоггүй хөрөнгийн хувьд, ашиглалтын үнэ цэнэ нь орлуулагч болгон орлуулалтын өртгийг ашигладаг. Орлуулалтын өртөг нь орох үнэ цэнэ юм. Мөнгө бий болгодоггүй хөрөнгийн хувьд ашиглалтын үнэ цэнэ нь тухайн хөрөнгийг ашиглаж байх явцад, орох үнэ цэнийн хэтийн төлөвтэй, харин түүнийг борлуулах үед гарах үнэ цэнийн хэтийн төлөвтэй байдаг. Иймээс ашиглалтын үнэ цэнэ нь орох ба гарах үнэ цэнийн аль алины хэтийн төлөвтэй болохыг заахгүй орхигдуулснаар улсын секторын нөхцөл байдлыг тусган харуулахгүй гэсэн байр суурийг зарим хүмүүс илэрхийлэхэд хүргэдэг. УСНББОУСЗ нь энэхүү байр суурийг хүлээн зөвшөөрсөн боловч ашиглалтын үнэ цэнийг тооцоолох орлуулагч болгон орлуулалтын өртгийг ашиглах нь ашиглалтын үнэ цэнэ өөрөө орох үнэ цэнэ боллоо гэсэн утга илэрхийлэхгүй гэж үзсэн. Иймээс ашиглалтын үнэ цэнэ

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

нь мөнгө бий болгогч ба мөнгө бий болгодоггүй хөрөнгийн аль алины хувьд гарах үнэ цэнэ байна гэж УСНББОУСЗ дүгнэсэн.

## Хөрөнгийн хэмжилтийн сууриуд

### Түүхэн өртөг

ДҮ7.15. Түүхэн өртөг бол олон улс оронд өргөнөөр ашигладаг хэмжилтийн суурь юм. Зөвлөлдөх Баримт Бичиг болон Саналын Төсөлд хариулт ирүүлсэн олон хүмүүс нь бусад хэмжилтийн сууриудтай ихэвчлэн хослуулах байдлаар түүхэн өртгийг хэмжилтийн суурь болгон цаашид өргөнөөр ашиглахыг дэмжсэн. Тэд хариуцлагын зорилт болон түүхэн өртгийн ойлгомжтой, шалгах боломжтой байдлыг харгалзсанаар энэхүү байр суурийг илэрхийлсэн. Түүхэн өртгийг бусад хэмжилтийн сууриудтай хослуулан өргөнөөр ашигладаг учраас түүнийг цаашид үргэлжлүүлэн ашиглах нь түүхэн өртөг ашиглахыг шаарддаг буюу зөвшөөрдөг одоогийн стандартад ирээдүйд засвар өөрчлөлт оруулснаар хэмжилтийн өөр суурь ашиглахыг шаардвал үүсэж болох өртөг зардлаас зайлсхийх боломжтой гэдгийг тэд бас тэмдэглэсэн.

ДҮ7.16. Түүхэн өртөг ба байгууллагын бодитойгоор хийсэн ажил гүйлгээний хоорондох уялдаа холбоо нь хариуцлагын үнэлгээнд ихээхэн ач холбогдолтой учраас түүхэн өртгийн мэдээлэл нь үйлчилгээний өртгийн тайлагналд хамгийн их хамааралтай мэдээллээр хангадаг гэж хариулт ирүүлсэн зарим хүмүүс үзэж байсан. Тухайлбал; нөөцөөр хангагчид нь тэдэнд ногдуулсан татварын үнэн зөв байдал эсвэл тайлант үед тэдний өөр бусад байдлаар оруулсан нөөцийг хэрхэн ашиглаж зарцуулсныг үнэлэхдээ ашиглаж болох мэдээллээр түүхэн өртөг нь хангадаг.

ДҮ7.17. Тухайн байгууллагын бодитоор гүйцэтгэсэн ажил гүйлгээний талаархи мэдээллээр хангах ба бодит ажил гүйлгээнд үндэслэсэн үйлчилгээний өртгийг хэрэглэгч нар сонирхож мэдэх боломж олгоход түүхэн өртөг нь олон нөхцөл байдалд хамааралтай байдаг гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрдөг. Түүхэн өртөг нь аль үйлчилгээ ирээдүйд ямар өртөгтэй байхыг биш, харин тухайн тайлант үед бодитойгоор ямар өртөг зардалтай байсан талаархи мэдээллээр хангадаг; түүхэн өртгийн мэдээлэлд үндэслэсэн үнэ тогтоох шийдвэр нь үйлчилгээний хэрэглэгчдэд шударга хандах боломжийг нэмэгдүүлж болох юм.

ДҮ7.18. Түүхэн өртгийг ашиглах нь санхүүгийн бодит үр дүн ба батлагдсан төсвийн хооронд харьцуулалт хийхэд туслалцаа үзүүлнэ гэж үздэг хүмүүсийн байр суурийг УСНББОУСЗ мөн хүлээн зөвшөөрсөн. Төсвийг ихэвчлэн түүхэн өртгийн сууриар бэлтгэж болох бөгөөд ингэснээр түүхэн өртөг нь төсөвтэй харьцуулалт хийх боломжийг нэмэгдүүлнэ гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрдөг.

ДҮ7.19. Үйлчилгээ үзүүлэхийн тулд зарцуулсан үнэ цэнийн нөхцлөөр тухайн үйлчилгээ үзүүлэх өртгийг үнэлж, тайлагнах нь шийдвэр гаргалтын болон хариуцлагын зорилгын аль алины хувьд ач холбогдолтой мэдээллээр

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

хангана гэсэн үүний эсрэг байр суурийг УСНББОУСЗ бас тэмдэглэсэн. Түүхэн өртөг нь хөрөнгийг ашиглан зарцуулах үеийн түүний үнэ цэнийг тусгадаггүй учраас үнийн өөрчлөлтийн үр нөлөө мэдэгдэхүйц хэмжээтэй байх тохиолдолд энэ нь тэрхүү нөхцөл байдал дахь үнэ цэнийн талаархи мэдээллээр хангадаггүй. Энэхүү эсрэг тэсрэг үзэл бодлын аль алинд Онолын үзэл баримтлалаар хариулт өгөх нь чухал ач холбогдолтой гэж УСНББОУСЗ дүгнэсэн.

**Зах зээлийн үнэ цэнэ ба бодит үнэ цэнэ**

ДҮ7.20. Саналын Төсөл нь бодит үнэ цэнийг хэмжилтийн суурь гэж үзээгүй. Харин Онолын үзэл баримтлалыг боловсруулж байх үед УСНББОУСЗ-ийн хэвлэл бүтээлд бодит үнэ цэнэтэй ижил байдлаар тодорхойлж байсан зах зээлийн үнэ цэнийг үүнд санал болгосон. Хариулт ирүүлсэн олон хүмүүс нь бодит үнэ цэнийг хэмжилтийн суурь болгон оруулахгүй орхисныг эсэргүүцсэн. Бодит үнэ цэнэ бол олон улсын болон үндэсний олон стандарт тогтоогчдын хэмжилтийн шаардлагуудыг илэрхийлэхэд ашиглаж, тодорхойлдог хэмжилтийн суурь бөгөөд бодит үнэ цэнийн тодорхойлолтыг УСНББОУСЗ-ийн хэвлэл бүтээлд өргөнөөр ашигладаг гэдгийг тэд цохон тэмдэглэсэн. Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д тодорхойлсноор, бодит үнэ цэнийн тодорхойлолт нь гарах үнэ цэнэ байвал зохино гэж бодит үнэ цэнийн олон дэмжигчид саналаа илэрхийлсэн.<sup>17</sup>

ДҮ7.21. Саналын Төсөлд УСНББОУСЗ-ийн санал болгосон хандлагын үндэслэл нь бодит үнэ цэнэ ба зах зээлийн үнэ цэнэ ижил төсөөтэй бөгөөд хэмжилтийн хоёр суурийн аль алиныг тусган оруулах нь санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийг будилахад хүргэж болох юм. СТОУС дахь бодит үнэ цэнэ нь мэдээж гарах үнэ цэнэ бөгөөд Онолын үзэл баримтлалыг боловсруулж байх үеийн УСНББОУСЗ-ийн хэвлэлд бүтээлд тусгасан бодит үнэ цэнийн тодорхойлолт байх магадлал багатай юм. Иймээс улсын сектор дахь бодит үнэ цэнийн хамааралтай байдал нь үйл ажиллагааны чадавхи болон үйлчилгээний өртгийн талаархи мэдээллээр хангах биш, харин санхүүгийн чадавхийн тухай мэдээллээр хангаснаар юуны өмнө хязгаарлагдах магадлалтай байдаг. Түүнчлэн, энэ бүлэгт авч хэлэлцсэн, орлуулалтын өртөг нь бодит үнэ цэнийг тодорхойлох үнэлгээний арга зүй биш, харин өөрийн эрхийн хүрээнд хэмжилтийн суурь байдаг.

ДҮ7.22. Улсын секторын хувьд олон хөрөнгө нь тусгайлсан шинжтэй бөгөөд иймээс орох ба гарах үнэ цэнийн хоорондох зөрүү мэдэгдэхүйц дүнтэй байдаг. Хөрөнгө нь өөрийн гарах үнэ цэнээс илүү үнэ цэнэ бүхий ирээдүйн үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөжөөр хангадаг тохиолдолд гарах үнэ цэнийг тусгасан хэмжүүр нь хамгийн их хамааралтай суурь биш байдаг. Үзүүлэх үйлчилгээний үнэ цэнэ буюу түүний ашиглалтаас хүлээгдэж буй мөнгөн гүйлгээ нь борлуулалтаас хүлээн авах үнэ цэнэтэй адил тийм их биш байх учраас нөөцийн хамгийн үр ашигтай зарцуулалт нь хөрөнгийг борлуулах явдал байх тохиолдолд хамгийн их хамааралтай хэмжилтийн суурь нь борлуулалтын өртгийг тусгах

---

<sup>17</sup> СТОУС 13, *Бодит Үнэ Цэнийн Хэмжилт*-д бодит үнэ цэнийн тодорхойлолтыг тусгасан.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

борлуулалтын цэвэр үнэ байх магадлалтай бөгөөд зах зээлийн нотолгоонд үндэслэх боловч нээлттэй, идэвхитэй, хэвийн зах зээл оршин байна гэж үздэггүй.

ДҮ7.23. Хэмжилтийн суурь болохын хувьд бодит үнэ цэнийн ач тусыг харгалзан үзэхдээ, УСНББОУСЗ нь санхүүгийн өгөөжийг үнэлэх хамааралтай суурийг бодит үнэ цэнээр бүрдүүлнэ гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгэдэг тохиолдолд зах зээлийн үнэ цэнэд агуулагдаж буй өгөөжийн хүрээнд санхүүгийн үр дүнг үнэлж болно. Гэвч улсын секторын үйл ажиллагааг ерөнхийдөө санхүүгийн үр өгөөж хүртэх зорилгоор гүйцэтгэдэггүй тул ийм аливаа өгөөжийн хамааралтай байдал хязгаарлагддаг.

ДҮ7.24. Хэмжилтийн бүлгийг эцэслэх үедээ УСНББОУСЗ нь энэхүү асуудлыг зохицуулах үндсэн гурван сонголтыг авч үзсэн:

- Гарах үнэ цэнэд үндэслэсэн бодит үнэ цэнийн тодорхойлолтыг батлан гаргах;
- Онолын үзэл баримтлалыг боловсруулахын өмнө УСНББОУС-д өмнө нь заасан, бодит үнэ цэнийн тодорхойлолтыг хэвээр хадгалах;
- Уг Саналын Төсөлд санал болгосончлон, бодит үнэ цэнийг биш, харин зах зээлийн үнэ цэнийг хэмжилтийн суурь байдлаар тусган оруулах.

ДҮ7.25. Гарах үнэ цэнэд үндэслэсэн бодит үнэ цэнийн тодорхойлолтыг мөрдөх нь мөнгөн гүйлгээ бий болгох бус, харин үйлчилгээ үзүүлэх гэсэн улсын секторын ихэнх байгууллагуудын зорилттой сайн нийцэхгүй тийм тодорхойлолтыг ашиглана гэсэн үг юм. Гарах үнэ цэнэд үндэслэсэн хэмжүүр нь үйл ажиллагааны чадавхийн зорилгоор эзэмшиж буй олон хөрөнгийн хувьд, түүнчлэн өр төлбөрийг шилжүүлэх боломжгүй тохиолдолд өр төлбөрийн хувьд хамааралтай мэдээллээр хангах эсэх нь эргэлзээтэй юм.

ДҮ7.26. Бодит үнэ цэнийн талаархи УСНББОУСЗ-ийн одоогийн тодорхойлолтыг болон Онолын үзэл баримтлал дахь энэхүү тодорхойлолтын бага зэрэг өөрчилсөн хувилбарыг тусган оруулах нь дэлхий нийтийн стандарт тогтоогч хоёр эх сурвалжийн хувьд нэг нэр томъёоны өөр өөр онолын тодорхойлолттой болоход хүргэх юм.

ДҮ7.27. Олон УСНББОУС нь хэмжилтийн шаардлага буюу сонголтондоо бодит үнэ цэнийг агуулсан байдаг учраас бодит үнэ цэнийг хэмжилтийн суурь болгон оруулахгүй байх нь Онолын үзэл баримтлалыг эцэслэн боловсруулах үед УСНББОУСЗ-ийн хүчин төгөлдөр хэвлэл бүтээлд нөлөө үзүүлнэ гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн.

ДҮ7.28. Бүх хүчин зүйлсийг харгалзан үзсэний эцэст, УСНББОУСЗ нь гарах үнэ цэнэд үндэслэсэн бодит үнэ цэнийн тодорхойлолт эсвэл бодит үнэ цэнийн талаархи улсын секторын тусгай тодорхойлолт оруулахын оронд, хэмжилтийн суурь болгон бодит үнэ цэнийг бус, харин зах зээлийн үнэ

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

цэнийг Онолын үзэл баримтлалд тусгах хэрэгтэй гэж дүгнэсэн. Бодит үнэ цэнэ нь хэмжилтийн тодорхой үр дүнг илэрхийлэх загвар гэж УСНББОУСЗ үздэг. Энэ Бүлэгт заасан хэмжилтийн сууриуд нь СТОУС-д хэрэгжүүлсэн бодит үнэ цэнэтэй хэрхэн уялдахыг тайлбарлахын тулд УСНББОУСЗ нь стандартын түвшинд цаашид тодорхой ажил хийж болох юм.

**Орлуулалтын өртөг, Борлуулалтын цэвэр үнэ, Ашиглалтын үнэ цэнэ**

ДҮ7.29. Улсын секторын байгууллагуудын зорилт нь ашиг олох бус, харин ихэвчлэн арилжааны бус ажил гүйлгээгээр үйлчилгээ үзүүлэх явдал байдаг учраас үйл ажиллагааны зорилгоор санхүүгийн бус олон хөрөнгүүдийг эзэмшдэг. Түүнчлэн, ийм олон хөрөнгүүд нь тусгайлсан шинжтэй бөгөөд нээлттэй, идэвхитэй, хэвийн зах зээлд тэдгээрийг худалдан авах буюу борлуулах магадлал багатай байдаг. Үйл ажиллагааны хөрөнгүүд нь тусгайлсан шинжтэй биш бөгөөд нээлттэй, идэвхитэй, хэвийн зах зээлд арилжигддаг тохиолдолд зах зээлийн үнэ цэнэ нь санхүүгийн болон үйл ажиллагааны чадавхийн үнэлгээнд туслалцаа үзүүлдэг. Гэвч хөрөнгө нь тусгайлсан шинжтэй бөгөөд зах зээлд үндэслэсэн мэдээлэл хязгаарлагдмал тохиолдолд үйлчилгээний өртөг ба үйл ажиллагааны чадавхийн талаархи ач холбогдолтой мэдээллээр хангахын тулд зах зээлийн үнэ цэнээс бусад, одоогийн хэмжилтийн сууриуд шаардлагатай байдаг.

ДҮ7.30. Тусгайлсан шинжтэй, үйл ажиллагааны хөрөнгийн талаархи хамгийн их ач холбогдолтой мэдээллээр хангах хэмжилтийн сууриудыг үнэлэхдээ, УСНББОУСЗ нь улсын секторын байгууллагуудын бараа, үйлчилгээний тасралтгүй нийлүүлэлтийг тусгах тийм суурийг эрэлхийлдэг. Ийм хөрөнгүүдийн хувьд хамгийн тохиромжтой суурь нь тухайн хөрөнгөд хамаарах үйлчилгээний чадавхийн өртгийн талаархи мэдээллээр хангадаг суурь юм.

ДҮ7.31. УСНББОУСЗ нь дахин үйлдвэрлэлийн өртгийг хэмжилтийн боломжит суурь гэж үздэг. Дахин үйлдвэрлэлийн өртөг нь хялбар ойлгомжтой байдаг. Гэвч энэ нь тухайн хөрөнгийн ханган бүрдүүлэх үйлчилгээний чадавхийг орлуулах өртөг зардлыг биш, харин адилтгах хөрөнгийг олж эзэмших өртгийг тусган илэрхийлдэг. Иймээс дахин үйлдвэрлэлийн өртөг нь эдийн засгийн аливаа зорилгоор цаашид үр өгөөжгүй хөрөнгийн тийм шинжүүдийг тусгаж болох бөгөөд энэ аргыг ашиглах нь хөрөнгийн үнэ цэнийг илүү илэрхийлэхэд хүргэж болох юм. Орлуулалтын өртөг нь тухайн хөрөнгийн үйлчилгээний чадавхийг орлуулахын тулд уг байгууллагад шаардлагатай хамгийн хэмнэлттэй өртөгт үндэслэдэг учраас ийм эрсдэлээс зайлсхийх боломж олгодог. Орлуулалтын өртгийг тооцоолоход зарим тохиолдолд төвөгтэй бөгөөд субъектив шүүн тунгаалт агуулдаг гэдгийг хүлээн зөвшөөрдөг боловч УСНББОУСЗ нь орлуулалтын өртөг бол хэмжилтийн зорилтыг ямагт хамгийн сайн хангаж, чанарын шинжүүдийг биелүүлдэг одоогийн үнэ цэнийн хэмжилт гэж дүгнэсэн. Орлуулалтын өртгийг хэрэгжүүлэх арга хандлагын талаархи стандартын түвшний заавар удирдамж шаардлага гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

ДҮ7.32. Орлуулалтын өртөг нь тусгайлсан шинжтэй, үйл ажиллагааны хөрөнгийн хувьд ямагт тохиромжтой хэмжилтийн суурь болж чадахгүй гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Байгууллага нь тухайн хөрөнгийг үргэлжлүүлэн ажиллуулах санаа зорилгогүй тийм нөхцөл байдал байж болох юм. Ийм нөхцөл байдалд хөрөнгийн ханган бүрдүүлэх үйлчилгээний чадавхийг орлуулах нь тухайн байгууллагын хувьд шалтгаан үндэслэлгүй учраас орлуулалтын өртөг нь ач холбогдолтой хэмжилтийн суурь болохгүй. Иймээс байгууллага нь ийм нөхцөл байдалд тохиромжтой хэмжилтийн суурийг авч үзсэн. Эдгээр нөхцөл байдалд тухайн байгууллагын хувьд борлуулалтын хязгаарлалтыг илэрхийлэх ба гарах үнэ цэнээр хангах байгууллагын тусгайлсан хэмжилтийн суурь илүү тохиромжтой байдаг. Борлуулалтын цэвэр үнэ нь энэхүү хэмжилтийн зорилтыг хамгийн сайн хангана гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Иймээс борлуулалтын цэвэр үнийг энэ бүлэгт хэмжилтийн суурь болгон оруулсан. Байгууллага нь магадгүй, нийгмийн болон улс төрийн зорилтыг биелүүлэхийн тулд хөрөнгөө зах зээлийн үнээс бага дүнгээр борлуулахыг гэрээгээр буюу заавал биелүүлэх хэлцлээр шаардсан тохиолдолд борлуулалтын цэвэр үнэ нь хэмжилтийн зорилтыг биелүүлэх тийм мэдээллээр бас хангадаг.

ДҮ7.33. Улсын секторын байгууллагуудын үйл ажиллагаагаа явуулж буй нөхцөл байдлын иж бүрэн шинжилгээ хийхийн тулд УСНББОУСЗ нь тухайн хөрөнгөнд агуулагдаж буй үйлчилгээний чадавхийг орлуулахад байгууллагын хувьд оновчтой биш боловч уг хөрөнгийг нэн даруй борлуулахын оронд үргэлжлүүлэн ажиллуулах нь байгууллагад илүү оновчтой хэвээр байх тийм нөхцөл байдлыг мөн авч үзсэн. Ашиглалтын үнэ цэнэ нь хөрөнгийг үргэлжлүүлэн ажиллуулснаас үүсэх мөнгөн гүйлгээ буюу үйлчилгээний чадавхи, түүнчлэн борлуулалтын орлогыг агуулсан байдаг. Иймээс УСНББОУСЗ нь ашиглалтын үнэ цэнийг боломжит хэмжилтийн суурь байдлаар тусган оруулах хэрэгтэй гэж дүгнэсэн. Энэхүү хэмжилтийн суурь нь мөнгө бий болгодоггүй нөхцөлд хэрэглэхэд хялбар биш учраас ашиглалтын үнэ цэнийг тодорхойлохдоо орлуулагч болгон орлуулалтын өртгийг ашиглах шаардлагатай байж болно гэж УСНББОУСЗ мэдэгдсэн.

### **Бодит үнэ цэнийн загвар**

ДҮ7.34. ДҮ7.20-р параграфт заасанчлан, өөрийн бүрэн эрхийн хүрээнд Саналын Төсөл нь бодит үнэ цэнийг хэмжилтийн суурь гэж санал болгоогүй. Хэдийгээр зах зээлийн үнэ цэнэ нь хэмжилтийн тохиромжтой суурь боловч зах зээл нь идэвхигүй, эсвэл нээлттэй биш буюу хэвийн бус тохиолдолд хэмжилтийг тооцоолох арга болгон бодит үнэ цэнийн хэмжилтийн загварыг санал болгодог.

ДҮ7.35. Саналын Төсөлд хариулт ирүүлсэн цөөн хүмүүс нь бодит үнэ цэнийн хэмжилтийн загварыг дэмжсэн. УСНББОУСЗ нь үүний хэрэглээний талаархи цаашдын дэлгэрэнгүй мэдээллээр хангавал зохино гэж хариулт ирүүлсэн зарим хүмүүс үзэж байсан. Өөр зарим хүмүүс нь уг загварыг дэмжсэн боловч Онолын үзэл баримтлалын хувьд хэмжилтийн дэлгэрэнгүй загвар тохиромжгүй гэж үзсэн. Хариулт ирүүлсэн зарим хүмүүс нь үүнийг стандартын түвшинд тооцооллын арга зүй байдлаар авч үзэх хэрэгтэй

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

гэсэн санал илэрхийлсэн. Хариулт ирүүлсэн олон хүмүүс нь СТОУС-ын тодорхойлолтыг ашигласнаар түүний эрхийн хүрээнд бодит үнэ цэнийг хэмжилтийн суурь болгон санал болгох хэрэгтэй гэсэн байр суурийг илэрхийлсэн боловч өөр зарим хүмүүс нь хэмжилтийн суурь байдлаар түүнийг батлан мөрдөхийн тулд бодит үнэ цэнийг тооцоолох хандлагын талаархи илүү дэлгэрэнгүй мэдээллийг хүссэн. Харин эсрэгээр, хариулт ирүүлсэн зарим хүмүүс нь улсын секторын хувьд бодит үнэ цэнэ тохиромжгүй гэсэн байр суурийг илэрхийлсэн.

ДҮ7.36. Бодит үнэ цэнийн загвар нь Онолын үзэл баримтлалд тусгахад хэт доод түвшний асуудал гэж үздэг хүмүүсийн байр суурийг УСНББОУСЗ нь анхаарч харгалзсан. Бодит үнэ цэнийг хэмжилтийн суурь болгон тодорхойлохгүй боловч уг загвараар дамжуулан бодит үнэ цэнийг дахин нэвтрүүлэх нь эргэлзээ төрүүлнэ гэж үздэг хүмүүсийн байр суурийг УСНББОУСЗ нь мөн хүлээн зөвшөөрсөн. Иймээс УСНББОУСЗ нь энэхүү сүүлийн бүлэгт бодит үнэ цэнийн загварыг тусган оруулахгүй байхаар шийдвэрлэсэн.

#### **Алдагдсан үнэ цэнийн загвар**

ДҮ7.37. Одоогийн үнэ цэнийн суурийг сонгох шалтгаан үндэслэл болгон алдагдсан үнэ цэнийн загварыг Зөвлөлдөх Баримт Бичигт авч хэлэлцсэн. Хариулт ирүүлсэн зарим хүмүүс нь энэхүү загварт эргэлзэж буйгаа илэрхийлсэн. Тухайлбал; уг загвар нь ихээхэн өртөг зардалтай бөгөөд суурь тус бүрээр хөрөнгийг тайлагнаж болох тэдгээр хэмжилтийн боломжит гурван суурийг тайлан бэлтгэгч нар харгалзан үзэхэд хүргэх хэвийн бус ачаалал үүсгэдэг. Энэ нь хэт нарийн төвөгтэй гэж хариулт ирүүлсэн олон хүмүүс мөн үзэж байсан. Алдагдсан үнэ цэнийн загвар нь хамааралтай байх чанарын шинжид хэт их ач холбогдол өгөх ба бусад чанарын шинжүүдийг үгүйсгэдэг гэсэн байр суурийг бас илэрхийлсэн.

ДҮ7.38. Алдагдсан үнэ цэнийн загварыг зарим улс оронд амжилттай мөрдөж буйг УСНББОУСЗ мэдэгдсэн боловч ийм эргэлзээг бүрэн буюу хэсэгчлэн хүлээн зөвшөөрсөн. Иймээс одоогийн хэмжилтийн суурийг ашиглахаар шийдвэрлэсэн боловч санхүүгийн тайлагналын зорилтууд болон чанарын шинжүүдийг лавлагаа болгосноор тохиромжтой суурийг тодорхойлж чадахгүй тохиолдолд орлуулалтын өртөг, борлуулалтын цэвэр үнэ, ашиглалтын үнэ цэнээс сонголт хийх боломжит арга болгон УСНББОУСЗ нь алдагдсан үнэ цэнийн загварыг Саналын Төсөлд тусган оруулсан.

ДҮ7.39. Саналын Төсөлд хариулт ирүүлсэн цөөхөн хүмүүс нь алдагдсан үнэ цэнийн загварыг ихээхэн дэмжсэн боловч олон хүмүүс нь уг загварын хэт нарийн төвөгтэй байдлын талаар өөрсдийн эргэлзээг илэрхийлсэн хэвээр байсан. УСНББОУСЗ нь алдагдсан үнэ цэнийн загварын техникийн дутагдалтай талыг бас илэрхийлсэн. Хэрэв борлуулалтын цэвэр үнэ нь орлуулалтын өртгөөс өндөр бол хөгжлийн боломж байгааг харуулж болох бөгөөд алдагдсан үнэ цэнийн загвараар бүрдүүлдэггүй боловч ийм мэдээллээр хэрэглэгчдийг хангах хэрэгтэй байдаг. Эдгээр хүчин зүйлсийн улмаас УСНББОУСЗ нь алдагдсан үнэ цэнийн загварыг Онолын үзэл баримтлалд

## УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

оруулахгүй байхаар шийдвэрлэсэн. Гэвч орлуулалтын өртөг, борлуулалтын цэвэр үнэ, ашиглалтын үнэ цэнийн хоорондох харилцан хамаарлын шинжилгээнд уг загварын илэрхийлэх зарим санаа хэвээр хадгалагддаг. Тухайлбал; борлуулалтын цэвэр үнэ ба ашиглалтын үнэ цэнийн аль өндөр нь орлуулалтын өртгөөс бага байвал тухайн хөрөнгийг орлуулалтын өртгөөр хэмжих нь тохиромжгүй байдаг.

### **Нэр төдий үнэ цэнэ**

ДҮ7.40. Зарим улс оронд тодорхой зарим хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд нэр төдий үнэ цэнээр, ихэвчлэн толилуулгын валютын нэг мөнгөн нэгжээр хүлээн зөвшөөрдөг. Үнэ цэнийн дүнг олж авахад хүндрэлтэй тохиолдолд хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрөхийн тулд ийм аргыг хэрэглэдэг. Энэ нь санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ач холбогдолтой мэдээллээр хангах бөгөөд хөрөнгийн удирдлага ба нягтлан бодох бүртгэлийн процессын хоорондох уялдаа холбоонд тусалцаа үзүүлдэг гэж нэр төдий үнэ цэнийг дэмжигчид үздэг.

ДҮ7.41. Ийм хандлага нь ач холбогдолтой мэдээллээр хангах санаа зорилготой гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрдөг. Гэвч нэр төдий үнэ цэнэ нь санхүүгийн чадавхи, үйл ажиллагааны чадавхи, үйлчилгээний өртгийн талаар хамааралтай мэдээллээр хангадаггүй учраас хэмжилтийн зорилтыг биелүүлэхгүй гэсэн байр суурийг УСНББОУСЗ-ийн ихэнх гишүүд илэрхийлсэн. Тухайн зүйл нь хөрөнгийн тодорхойлолт ба Бүлэг 5, *Санхүүгийн Тайлангийн Элементүүд*, Бүлэг 6, *Санхүүгийн Тайлан дахь Хүлээн Зөвшөөрөлт*-д заасан, хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангах эсэхийг үнэлсэний дараа тэрхүү зүйлийг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шийдвэрийг гаргах хэрэгтэй гэж УСНББОУСЗ-ийн ихэнх гишүүд дүгнэсэн. Үнэ цэнийг олж мэдэх боломжгүй буюу ихээхэн өртөг зардалтай тохиолдолд тодруулгаар дамжуулан ханган бүрдүүлэх мэдээллийг стандартын түвшинд хянамгай авч үзэх нь чухал ач холбогдолтой гэдгийг УСНББОУСЗ мөн хүлээн зөвшөөрсөн.

### **Өр төлбөрийн хэмжилтийн сууриуд**

#### **Үүрэг хариуцсаны үнэ ба чөлөөлөгдөх өртөг**

ДҮ7.42. Үүрэг хариуцсаны үнэ ихэвчлэн байдаггүй арилжааны бус ажил гүйлгээгээр дамжуулан улсын секторын байгууллагууд нь олон үйлчилгээг үзүүлдэг гэж үздэг хүмүүсийн байр суурийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Үүрэг хариуцсаны үнэ нь хэмжилтийн зорилтыг хангах тийм нөхцөл байдал хязгаарлагдмал цөөхөн гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Гэвч даатгал, түүнчлэн санхүүгийн баталгаа гэх мэт адилтгах үүрэг нь хамааралтай ба үнэн зөв илэрхийлэл болох мэдээллийг уг үүрэг хариуцсаны үнээр ханган бүрдүүлж болох тийм өр төлбөрүүд юм. Ийм тохиолдолд анхны хүлээн зөвшөөрөлтийн дараах эрсдлийн урамшууллын өөрчлөлтийг тусгахын тулд үүрэг хариуцсаны үнээр өр төлбөрийг дахин үнэлж болох юм.



УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

ДҮ7.43. Саналын Төсөлд хариулт ирүүлсэн зарим хүмүүс нь чөлөөлөгдөх өртгийг оруулах хэрэгтэй эсэхийг бас асуусан. Улсын секторын хувьд үүрэг хариуцагчаас өр төлбөрийг тодорхой дүнгээр шилжүүлэн авахад бэлэн, тийм гаднын этгээд байдаггүй учраас ихэнх тохиолдолд ялангуяа арилжааны бус ажил гүйлгээнд чөлөөлөгдөх өртөг гаргах магадлал багатай гэж УСНББОУСЗ мэдэгдсэн. Чөлөөлөгдөх өртгийг тодорхойлох боломжтой байлаа ч гэсэн тухайн гаднын тал нь өр төлбөрийг барагдуулах гүйцэтгэлийн өртгөөс бага дүнг хүлээн зөвшөөрөх магадлал багатай юм. Иймээс арилжааны бус ажил гүйлгээгээр үүссэн өр төлбөрийг гүйцэтгэлийн өртгөөр хэмжих магадлалтай бөгөөд энэ нь ихэвчлэн практикт хэрэгжих боломжтой, хамааралтай цорын ганц хэмжилтийн суурь болдог. Гэвч үүрэг хариуцсаны үнэ ба чөлөөлөгдөх өртөг нь хэмжилтийн зорилтыг хангах цөөн хязгаарлагдмал нөхцөл байж болох тул УСНББОУСЗ нь эдгээрийг Онолын үзэл баримтлалд хэмжилтийн суурь болгон оруулахаар шийдвэрлэсэн.

### **Бусад асуудал**

ДҮ7.44. Хэмжилттэй холбоотой дараах хоёр асуудлын хувьд Зөвлөлдөх Баримт Бичиг нь хариулт ирүүлсэн хүмүүсээс санал авахыг эрмэлзсэн:

- Байгууллагын өөрийн зээлийн эрсдэл, түүнчлэн тухайн байгууллагын өөрийн зээлийн эрсдлийн өөрчлөлтөнд хамаарах үнэ цэнийн өөрчлөлтийн бүртгэлийн арга хандлага;
- Хөрөнгийн хэмжилт нь түүний зөвхөн одоогийн ашиглалттай холбоотой үйлчилгээний чадавхийг тусгах, эсвэл хөрөнгийн хэмжилт нь түүний боломжит хувилбар ашиглалттай холбоотой өсөн нэмэгдэх үнэ цэнийг тусгах хэрэгтэй эсэх.

ДҮ7.45. Дээрх асуудлуудын талаар саналаа ирүүлсэн ихэнх хүмүүс нь эдгээр асуудлыг Онолын үзэл баримтлалд биш, харин стандартын түвшинд илүү зохистойгоор авч үзэх хэрэгтэй гэж үзсэн. УСНББОУСЗ нь ийм байр суурьтай санал нэг байсан бөгөөд иймээс эдгээр асуудлыг Онолын үзэл баримтлалд авч үзээгүй. Өр төлбөрийг хэмжихийн тулд зах зээлийн үнэ цэнийг ашигладаг тохиолдолд тухайн байгууллагын өөрийн зээлийн эрсдлийг бүртгэх арга хандлагыг харгалзах шаардлагатай гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн.

## **БҮЛЭГ 8: НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН ДАХЬ ТОЛИЛУУЛГА**

### **АГУУЛГА**

---

	Параграф
Танилцуулга	8.1-8.8
Толилуулга	8.4-8.8
Мэдээллийн сонголт	8.9-8.35
Мэдээллийн сонголт – Мэдээллийн шинж төрөл	8.11-8.14
Тайлагнал эсвэл тодруулгын зорилгоор сонгосон мэдээлэл	8.15-8.24
Мэдээллийн сонголтонд мөрдөх зарчим	8.25-8.35
Мэдээллийн байршил	8.36-8.44
Янз бүрийн тайланд мэдээллийг хуваарилах зарчим	8.38-8.40
Тайланд мэдээллийг байршуулах зарчим	8.41-8.44
Мэдээллийн зохион байгуулалт	8.45-8.64
Зохион байгуулалтанд хамаарах мэдээллийн шинж төрөл	8.47-8.53
Мэдээллийн зохион байгуулалтанд мөрдөх зарчим	8.54-8.64
Дүгнэлтийн үндэслэл	

---

## Танилцуулга

- 8.1 НЗСТ-д, үүн дотроо засгийн газрын болон улсын секторын бусад байгууллага (байгууллагууд)-ын санхүүгийн тайланд мэдээллийг толилуулахад мөрдөх ойлголт ухагдахууныг энэ Бүлэгт тодорхойлсон.
- 8.2 Толилуулга нь Бүлэг 1-4-тэй холбоотой байдаг. Санхүүгийн тайлагналын зорилт, хэрэглэгчдийн хэрэгцээ, чанарын шинжүүд, НЗСТ-д тусгасан мэдээллийн хязгаарлалт, тайлагнагч байгууллага зэрэг нь толилуулгын шийдвэрт бүгд нөлөө үзүүлдэг. Санхүүгийн тайланд тайлагнасан мэдээллийн хувьд, толилуулга нь Бүлэг 5-7-д дурдсан, элементүүдийн тодорхойлолт, хүлээн зөвшөөрөлтийн шалгуур, хэмжилтийн сууриудтай бас холбоотой байдаг. Тухайлбал:
- Элементүүдийн тодорхойлолт нь санхүүгийн тайланд толилуулж болох зүйлсэд нөлөөлдөг;
  - Хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын мөрдөлт нь мэдээллийн байршилд нөлөөлдөг;
  - Хэмжилтийн сууриудын сонголт нь хэмжилтийн арга зүйн дагуу толилуулсан мэдээлэлд нөлөөлдөг.

### *Санхүүгийн тайлан болон бусад НЗСТ-г бэлтгэн гаргасан хэл*

- 8.3 Санхүүгийн тайлан болон бусад НЗСТ-г бэлтгэн гаргасан хэл (буюу хэлүүд) нь санхүүгийн тайлагналын зорилтууд ба чанарын шинжүүдийг хангахад дэмжлэг үзүүлдэг. Орчуулагдсан бүх хувилбар нь эх хэл дээрх хувилбарын үнэн зөв илэрхийлэл байх ёстой. Хэрэглэгчдийн хэрэгцээг хангахын тулд дараах зүйлсийг лавлагаа болгон харгалзсанаар уг орчуулагдсан хувилбарыг хэрэглэгчдэд танилцуулдаг:
- Тухайн байгууллагын үйл ажиллагаа явуулдаг улс орны хууль эрх зүйн шаардлага;
  - Орчуулгын зардал ба үр өгөөж.

## Толилуулга

- 8.4 Толилуулга нь НЗСТ-д тайлагнасан мэдээллийн сонголт, байршил, зохион байгуулалт юм.
- 8.5 Толилуулга нь НЗСТ-д тусгасан мэдээллийн хязгаарлалтуудыг харгалзахын зэрэгцээгээр тухайн санхүүгийн тайлагналын зорилтууд болон чанарын шинжүүдийг биелүүлэхэд хувь нэмрээ оруулах тийм мэдээллээр хангах явдал юм. Эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийн талаархи хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээг хангахын тулд мэдээллийн сонголт, байршил, зохион байгуулалтын хувьд шийдвэр гаргадаг.
- 8.6 НЗСТ нь янз бүрийн олон тайлангаас бүрдэх бөгөөд тайлан бүр нь санхүүгийн тайлагналын зорилтуудын тодорхой төлөв байдал болон санхүүгийн тайлагналын цар хүрээнд хамаарах асуудлуудад илүү шууд

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

хариулт өгдөг гэдгийг Бүлэг 1-д тайлбарласан. Санхүүгийн тайлангаас гадна НЗСТ нь тухайлбал, байгууллагын үйлчилгээний гүйцэтгэл ба түүний санхүүгийн тогтвортой байдлын үнэлгээнд хамааралтай мэдээллээр хангадаг. Тухайн тодорхой тайланд тусгагдах талбарын хувьд хамаарах санхүүгийн тайлагналын зорилтууд нь тэрхүү тайлангийн талаархи толилуулгын шийдвэрийн удирдамж болдог.

8.7 Толилуулгын шийдвэр нь дараах үр дагавартай байж болно:

- Шинэ НЗСТ-г боловсруулах, тайлангуудын хооронд мэдээллийг шилжүүлэх эсвэл одоо байгаа тайлангуудыг нэгтгэх;
- НЗСТ-гийн хүрээнд мэдээллийн сонголт, байршил, зохион байгуулалтын талаар нарийвчилсан шийдвэр гаргах.

*Толилуулгын талаархи шийдвэрүүд харилцан уялдах*

8.8 Мэдээллийн сонголт, байршил, зохион байгуулалтын талаархи шийдвэрүүд нь хоорондоо харилцан уялдаатай бөгөөд практикт тэдгээрийг хамтад нь авч үзэх магадлалтай байдаг. Сонгосон мэдээллийн хэмжээ болон төрөл нь түүнийг тусдаа тайланд тусган оруулах, эсвэл хүснэгт буюу тусдаа хөтөлбөр байдлаар зохион байгуулах эсэхэд нөлөө үзүүлж болох юм. Дараах гурван хэсэг Толилуулгын талаархи шийдвэр бүрийг дараах гурван хэсэгт тус тусад нь авч үзсэн.

### **Мэдээллийн сонголт**

8.9 Дараах тайланд ямар мэдээлэл тайлагнах эсэхийг мэдээллийн сонголтын талаархи шийдвэрт авч үздэг:

- Санхүүгийн тайлан; ба
- Санхүүгийн тайланд хамаарахгүй НЗСТ-д (бусад НЗСТ).

8.10 Бүлэг 2, *Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Зорилтууд ба Хэрэглэгчид*-д тайлбарласанчлан, санхүүгийн тайлагналын зорилтууд нь хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд НЗСТ-гийн хэрэглэгчдэд ач холбогдолтой, тухайн байгууллагын талаархи мэдээллээр хангах явдал юм. Санхүүгийн тайлагналын зорилтуудыг хангахын тулд хэрэглэгчдэд шаардлагатай мэдээллийн төрлүүдийг Бүлэг 2-т тодорхойлсон. Ийм тайлбар тодорхойлолт нь тухайн төрлийн тайлан шаардлагатай эсэх шийдвэрийг удирдан чиглүүлдэг. НЗСТ-д, үүн дотроо санхүүгийн тайлан болон бусад тайлан илтгэлд толилуулах мэдээллийн сонголтыг энэ Бүлэгт голлон авч үзнэ.

### **Мэдээллийн сонголт – Мэдээллийн шинж төрөл**

*Санхүүгийн тайлан дахь мэдээллийн шинж төрөл*

8.11 Бүлэг 2-т тодорхойлсон, хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээ нь санхүүгийн тайлангийн зорилго бүхий мэдээллийн сонголтонд үндэслэдэг. Эдгээр

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

хэрэгцээ нь дараах боломжийг олгох тухайн байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний талаархи мэдээллийг агуулсан байдаг:

- Тухайн тайлангийн өдрөөр уг байгууллагын нөөц болон тэдгээр нөөцийн нэхэмжлэлийг тодорхойлох боломжийг хэрэглэгчдэд олгох;
- Байгууллага нь нөөцийг хэмнэлттэйгээр олж эзэмшсэн ба өөрийн үйлчилгээ үзүүлэх зорилгод хүрэхийн тулд түүнийг үр ашигтай, үр дүнтэй ашигласан эсэх гэх мэт асуудлуудын үнэлгээг мэдээлэх;
- Санхүүгийн үр дүн, байгууллагын хөрвөх чадвар ба төлбөрийн чадварын үнэлгээг мэдээлэх.

8.12 Санхүүгийн тайлан нь мөн дараах зүйлийг үнэлэхэд хэрэглэгчдэд туслах мэдээллээр хангаж болох юм:

- Байгууллага нь өөрийн санхүүгийн зорилтуудыг биелүүлсэн эсэх;
- Тухайн байгууллагын орлого, зардал, мөнгөн гүйлгээ, санхүүгийн үр дүн нь батлагдсан төсөвтэй нийцэж буй эсэх;
- Байгууллага нь төрийн мөнгөний бүрдүүлэлт ба ашиглан зарцуулалтыг зохицуулах холбогдох хууль тогтоомж буюу бусад бүрэн эрхийг даган мөрддөг эсэх.

8.13 Байгууллагын үйлчилгээний гүйцэтгэлийн талаар санхүүгийн тайланд дэлгэрэнгүй тайлагнадаггүй. Гэвч санхүүгийн тайлан дахь мэдээлэл нь үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүгийн төлөв байдалд хамааралтай дараах гэх мэт зүйлсийн талаархи мэдээллээр хангаж болох юм. Үүнд:

- Үйлчилгээтэй холбоотой орлого, зардал, мөнгөн гүйлгээ;
- Үйлчилгээ үзүүлэхэд нөлөөлж болох тухайлбал, тухайн байгууллагын үйл ажиллагааны чадавхи буюу санхүүгийн эрсдлийн талаархи хэрэглэгчдийн үнэлгээнд зориулсан мэдээлэл болох хөрөнгө ба өр төлбөр.

8.14 НЗСТ дахь бусад тайлангууд нь санхүүгийн тайлангийн нэмэлт болох мэдээллийг толилуулдаг. Ийм мэдээлэлд тухайлбал, дараах зүйлс хамаарч болно:

- Тухайн байгууллагын төрийн санхүүгийн тогтвортой байдлын талаархи мэдээлэл;
- Санхүүгийн тайлангийн хэлэлцүүлэг ба шинжилгээ;
- Үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээлэл.

**Тайлагнал эсвэл тодруулгын зорилгоор сонгосон мэдээлэл**

8.15 Мэдээллийг НЗСТ-д тайлагнах эсвэл тодруулах зорилгоор сонгодог. Тайлагнах зорилгоор сонгосон мэдээлэл нь НЗСТ дахь гол утга санааг хүргэн танилцуулдаг бол тодруулгын зорилгоор сонгосон мэдээлэл нь

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

тэрхүү тайлагнасан мэдээллийг ойлгоход хэрэглэгчдэд туслах дэлгэрэнгүй мэдээллээр хангаснаар уг тайлагнасан мэдээллийг илүү их ач холбогдолтой болгодог. Тодруулга нь тайлагналыг орлохгүй юм.

- 8.16 НЗСТ-д мэдээллийг дахин давтахаас ерөнхийдөө зайлсхийх хэрэгтэй. Гэвч нэг ижил мэдээллийг тайлагнаж, мөн тодруулж болох юм. Жишээлбэл; санхүүгийн тайлангийн тэмдэглэл нь тухайн тайлагнасан нийт дүнгийн задаргааг харуулдаг тохиолдолд санхүүгийн тайланд тайлагнасан нийт дүнг тэмдэглэл хэсэгт дахин давтаж болно. Үүнтэй адилаар, тухайн нэг мэдээллийн янз бүрийн зорилгыг харгалзан тусгахын тулд нэг ижил мэдээллийг өөр өөр НЗСТ-д толилуулж болно.

*Тайлагналын зорилгоор сонгосон мэдээлэл*

- 8.17 НЗСТ бүр нь өөрийн хүргэн танилцуулах гол утга санааг агуулдаг тул НЗСТ нэг бүр нь тайлагнасан мэдээллийг агуулсан байдаг. Хэрэглэгчид нь толилуулсан гол утга санаанд төвлөрөх ба тэдгээр гол утга санааг бүрхэгдүүлж болох дэлгэрэнгүй зүйлсэд анхаарал сарниулахгүйн тулд тайлагнасан мэдээллийг товч тодорхой, ойлгомжтой түвшинд байлгадаг. Тодорхой нэр хаяг, хүрээ шугам, хүснэгт, график гэх мэт толилуулгын тохиромжтой арга зүй ашигласнаар тухайн тайлагнасан мэдээллийг ихэвчлэн илэрхийлдэг.
- 8.18 Санхүүгийн тайланд тайлагнасан зүйлс нь тухайн тайлагнагч байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ гэх мэт асуудлын талаархи мэдээллээр хангадаг.
- 8.19 Хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг тухайн зүйл хангах эсэх үнэлгээ нь уг мэдээллийг санхүүгийн байдлын тайланд эсвэл санхүүгийн үр дүнгийн тайланд тайлагнах ба/буюу тэмдэглэл хэсэгт эсвэл НЗСТ-гийн өөр аль нэг хэсэгт тодруулах эсэхийг тодорхойлох гол замуудын нэг юм. Бусад тохиолдолд жишээлбэл, мөнгөн гүйлгээний тайлангийн хувьд, тухайн тайлагнасан мэдээлэл нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг биелүүлэхэд мөн дэмжлэг үзүүлдэг.
- 8.20 Мөрийн зүйлс болон нийт дүнг тусган харуулах шаардлагууд нь ойлгомжтой байдалд дэмжлэг үзүүлэх тухайн тайлагнасан мэдээллийн нэг хэвийн стандартчилал ба уг байгууллагын тусгайлсан хүчин зүйлсэд нийцсэн мэдээлэл хоорондох тэнцвэрийг харгалзсан байдаг. Стандартчилсан нэг хэвийн тайлагналын шаардлагууд ба байгууллагын тусгайлсан мэдээллийн аль алины зорилго нь тухайн байгууллагын мөн чанар ба үйл ажиллагааг тусгах тийм арга маягаар мэдээллийг тайлагнах боломж олгохоос гадна, санхүүгийн тайлагналын зорилтуудыг биелүүлэхэд хэрэгцээтэй уг мэдээлэл нь бүх байгууллагуудын хувьд бэлэн боломжтой эсэхийг ханган магадлах явдал юм.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

*Тодруулгын зорилгоор сонгосон мэдээлэл*

- 8.21 Тодруулсан мэдээлэл нь дараах зүйлсийг агуулсан байх магадлалтай байдаг. Үүнд:
- Мөрдөх бодлого буюу арга зүй гэх мэт тухайн тайлагнасан мэдээллийн суурь;
  - Тайлагнасан мэдээллийн задаргаа;
  - Тайлагнасан мэдээллийн бүх биш боловч зарим төлөв байдлыг илэрхийлэх зүйлс. Жишээлбэл; элементийн тодорхойлолтын<sup>18</sup> бүх биш боловч зарим шинж чанарыг хангах зүйлсийн талаархи тодруулга эсвэл элементийн тодорхойлолтыг хангах боловч хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангахгүй зүйлсийн талаархи тодруулга.
- 8.22 Тодруулсан мэдээллээр хангах хэт нуршуу биш дэлгэрэнгүй мэдээлэл нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг биелүүлэхэд хувь нэмрээ оруулдаг. Санхүүгийн тайлагналын зорилтуудыг биелүүлэхэд, тодруулсан мэдээлэл нь тайлагнасан мэдээлэлтэй нэгэн адил зайлшгүй шаардлагатай байдаг.
- 8.23 Санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тодруулсан мэдээлэл нь:
- Санхүүгийн тайлангийн талаархи хэрэглэгчдийн ойлголтонд зайлшгүй шаардлагатай байдаг;
  - Тухайн байгууллагын болон түүний үйл ажиллагааны орчны хүрээнд санхүүгийн тайланг толилуулах тийм мэдээллээр хангадаг;
  - Санхүүгийн тайланд тайлагнасан бөгөөд өөрийн хамаарах мэдээлэлтэй ерөнхийдөө, илт тодорхой ба ойлгомжтой харилцаа холбоотой байдаг.
- 8.24 Тэмдэглэлд тодруулсан мэдээлэл нь мөн дараах зүйлсийг агуулсан байж болно:
- Тайлагнасан мэдээллийн талаархи шүүн тунгаалтанд нөлөөлж болох уг байгууллагатай холбоотой хүчин зүйлс (жишээлбэл; холбоотой талууд ба хяналтанд буй байгууллага буюу бусад байгууллагууд дахь хувь оролцооны талаархи мэдээлэл);
  - Тайлагнасан мэдээллийн суурь (жишээлбэл; нягтлан бодох бүртгэлийн бодлого ба хэмжилт, үүн дотроо хэмжилтийн аргууд, хэрэв хамааралтай бол хэмжилтийн тодорхойгүй байдлын талаархи мэдээлэл);
  - Санхүүгийн тайланд тайлагнасан дүнгийн задаргаа (жишээлбэл; үндсэн хөрөнгийн янз бүрийн ангиудаар харуулсан задаргаа);

---

<sup>18</sup> Элементийн тодорхойлолтыг хангахгүй бусад нөөц ба бусад үүргийг санхүүгийн тайлагналын зорилтуудад хувь нэмрээ оруулахын тулд хүлээн зөвшөөрч болно гэдгийг Бүлэг 5, *Санхүүгийн Тайлангийн Элементүүд*-д тайлбарласан.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

- Элементийн тодорхойлолт эсвэл хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангахгүй боловч тухайн байгууллагын санхүүгийн болон үйлчилгээ үзүүлэх чадавхийг ойлгоход чухал ач холбогдолтой зүйлс – Жишээлбэл; ирээдүйн мөнгөн гүйлгээ буюу үйлчилгээний чадавхид нөлөөлж болох үйл явдал ба нөхцөл байдал, үүн дотроо тэдгээрийн шинж төрөл, мөнгөн гүйлгээний болон үйлчилгээний чадавхид үзүүлэх боломжит үр нөлөө, гарч тохиолдох магадлал, нөхцөл байдлын өөрчлөлтөөс хамаарах мэдрэмжийн талаархи мэдээлэл;
- Тайлагнасан нийт дүнд нөлөөлөх үндсэн хандлагыг тайлбарлаж болох мэдээлэл.

**Мэдээллийн сонголтонд мөрдөх зарчим**

- 8.25 Тайлагнах ба тодруулах шаардлагатай мэдээллийн талаархи шийдвэрт дараах зүйлсийг харгалзан үздэг. Үүнд:
- Санхүүгийн тайлагналын зорилтууд;
  - НЗСТ-д тусгасан мэдээллийн чанарын шинжүүд ба хязгаарлалтууд;
  - Мэдээлэл шаардлагатай байж болох тухайн холбогдох эдийн засгийн болон бусад юмс үзэгдэл.
- 8.26 Мэдээллийн сонголт нь тодорхой тайланд хамаарах талбаруудад хэрэглэж, дэлгэрэнгүй байдлын зохих түвшинг хангаснаар санхүүгийн тайлагналын зорилтуудыг биелүүлэхэд хувь нэмрээ оруулах мэдээлэл бий болгох үр дүнтэй байдаг. Мэдээллийн сонголтын талаархи шийдвэр нь мэдээллийн эрэмбэ дараалал ба нэгтгэн товчоололтыг агуулдаг. Мэдээллийн сонголт нь ойлгомжтой байдлыг бууруулах мэдээллийн хэт ачааллаас зайлсхийдэг. Хэт их мэдээлэл нь гол утга санааг хэрэглэгч нар ойлгоход хүндрэл үүсгэх ба ингэснээр санхүүгийн тайлагналын зорилтуудын биелэлтэнд саад учруулж болох юм.
- 8.27 Тунхаглалууд болон мэргэжлийн шүүн тунгаалтыг ашиглаж буй тайлан бэлтгэгч нар нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг биелүүлэх ба чанарын шинжүүдийг хангах тийм мэдээллийг өөрсдийн бэлтгэж буй НЗСТ-д тусгасан эсэхийг ханган магадлах хариуцлага хүлээдэг.
- 8.28 Мэдээллийн сонголтын талаархи шийдвэр нь байнгын ба шүүмжлэлтэй нягтлах шалгалтыг шаарддаг. Хэдийгээр мэдээллийн сонголтын талаархи шийдвэрт бүх чанарын шинжүүд болон хязгаарлалтуудыг хэрэглэдэг боловч толилуулгын зорилгоор боловсруулж, харгалзан үзсэн тул боломжит сонголтын хувьд тодорхойлсон мэдээллийг түүний хамааралтай байдал, материаллаг байдал, өртөг-өгөөжийн харьцааг тусгайлан харгалзсанаар нягталж шалгадаг. Шинэ мэдээлэл нь тухайн зүйлс чанарын шинжүүд болон хязгаарлалтуудыг цаашид хангахгүй болгох байдлаар мэдээллийн одоогийн шаардлагууд хоцрогдоход хүргэж болох учраас өмнөх шийдвэрүүдийг дахин харгалзан үзэх шаардлагатай байж болох юм.



УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

- 8.29 Хамааралтай ба үнэн зөв толилуулга гэсэн чанарын шинжийг хангахын тулд тухайн тайлагнасан бүх материаллаг ажил гүйлгээ, үйл явдал болон бусад зүйлсийг тэдгээрийн хуулийн буюу бусад хэлбэрийг биш, харин мөн чанарыг илэрхийлэх тийм арга замаар толилуулна.
- 8.30 Мэдээлэл хүлээн авч буй хэрэглэгчдийн хүртэх өгөөж нь тухайн мэдээллийг цуглуулах ба толилуулахад уг байгууллагын гаргасан өртөг зардлыг зөвтгөн баталдаг байх шаардлагатай. Ийм үнэлгээг хийхдээ, тухайн толилуулсан ерөнхий төлөв байдал болон толилуулсан мэдээллийн шинж төрөлд тэдгээр бие даасан зүйлс хэрхэн нөлөө үзүүлэхийг харгалзах нь чухал ач холбогдолтой байдаг. Тусад нь авч үзэхэд маш бага өгөөжтэй мэт харагдаж болох зүйлс нь толилуулсан иж бүрэн цогц мэдээлэлд оруулах хувь нэмрийн хувьд маш их өгөөжтэй байж болно.
- 8.31 Хэрэглэгчид нь удирдлагыг хариуцлагатай байлгах боломж бүрдүүлэх ба хэрэглэгчдийн шийдвэрийг мэдээллээр хангахын тулд мэдээллийг цаг хугацаанд нь толилуулах ёстой.
- 8.32 НЗСТ нь санхүүгийн мэдээллийн системээс өөр бусад эх үүсвэрээс олж авсан нэмэлт мэдээллийг агуулсан байж болно. Ийм мэдээлэлд чанарын шинжүүдийг мөрдөнө. Тайлагнасан мэдээлэл нь цаг хугацаандаа байхын тулд ийм аливаа нэмэлт мэдээллийг хүргэх огноо нь санхүүгийн тайлангийн тайлагналын өдөртэй аль болох ойр байх шаардлагатай юм.

*Тайлагнал ба тодруулгын зорилгоор мэдээллийг сонгох зарчим*

- 8.33 Санхүүгийн тайлан болон бусад НЗСТ-гийн аль алины хувьд тайлагнах эсвэл тодруулах эсэх шийдвэрийг гаргана. Тайлагнах эсвэл тодруулах мэдээллийн танин тодорхойлолтыг удирдан чиглүүлэхийн тулд тухайн тайланд хамаарах талбарын хувьд санхүүгийн тайлагналын зорилтуудыг харгалзан мөрдөнө. Тухайн тодорхой НЗСТ-д тайлагнах болон тодруулах мэдээллийн тодорхойлолт нь дараах зүйлсийн боловсруулалтыг агуулсан байж болно. Үүнд:
- Ангиллын зарчим;
  - Тайлагнах мэдээллийн нийтлэг төрлүүдийн жагсаалт ба тодруулах мэдээллийн нийтлэг төрлүүдийн жагсаалт;
  - Тайлан бэлтгэгч нар нь тайлагнах эсвэл тодруулах ёстой тусгай мэдээллийн жагсаалт.
- 8.34 Тайлагнах болон тодруулах мэдээллийн сонголтын талаархи шийдвэрийг дараах байдлаар гаргадаг:
- Тус тусад нь биш, харин харилцан лавлагаа болгон харгалзсанаар;
  - Нэгдмэл цогц мэдээллийг үр дүнтэйгээр хүргэн танилцуулах.
- 8.35 Бусад НЗСТ ба санхүүгийн тайлангийн хоорондох харилцаа холбоог хянамгай анхаарч үзсэний дараа бусад НЗСТ дахь мэдээллийн хувьд сонголтын шийдвэрийг гаргадаг.

## Мэдээллийн байршил

- 8.36 Дараах зүйлсийн хувьд мэдээллийн байршлын талаархи шийдвэрийг гаргадаг:
- Тайлангийн мэдээллийг түүнд байршуулах;
  - Тайлангийн мэдээллийн бүрэлдэхүүн хэсгийг байршуулах.
- 8.37 Мэдээллийн байршил нь санхүүгийн тайлагналын зорилтууд болон чанарын шинжүүдийг биелүүлэхэд уг мэдээллийн оруулах хувь нэмэрт нөлөө үзүүлдэг. Байршил нь мэдээлэл болон тухайн мэдээллийн зэрэгцүүлэгдэх байдлыг хэрэглэгч нар тайлбарлах арга замд нөлөө үзүүлж болох юм. Дараах зорилгоор мэдээллийг ашиглаж болно:
- Мэдээллийн харьцангуй ач холбогдол ба мэдээллийн бусад зүйлстэй түүний холбогдох байдлыг илэрхийлэх;
  - Мэдээллийн шинж төрлийг илэрхийлэх;
  - Тухайн хэрэглэгчийн хэрэгцээг хангахын тулд нэгтгэн нийлүүлэх янз бүрийн мэдээллийн зүйлсийг өөр хооронд нь холбох;
  - Тайлагнахаар сонгосон мэдээлэл ба тодруулахаар сонгосон мэдээллийг өөр хооронд нь ялган тодорхойлох.

## Янз бүрийн тайланд мэдээллийг хуваарилах зарчим

- 8.38 Санхүүгийн тайлан ба бусад НЗСТ-гийн хооронд мэдээллийг хуваарилах талаархи шийдвэртэй холбоотой хүчин зүйлсэд доорх зүйлс хамаарна:
- *Шинж төрөл:* Харгалзан анхаарах зүйлс нь тухайлбал; зэрэгцүүлэгдэх боломжтой байдал ба/буюу ойлгомжтой байдалтай холбоотой тул мэдээллийн шинж төрөл, жишээлбэл; түүхэн эсвэл хэтийн эсэх нь тухайн мэдээллийг нэг тайланд эсвэл өөр НЗСТ-д тусган оруулах эсэхийг дэмжин илэрхийлдэг;
  - *Улс орны тусгайлсан шинж:* Хуулийн заалт гэх мэт улс орны тусгай хүчин зүйлс нь мэдээллийн байршлын талаархи шаардлагуудыг тусгайлан заадаг эсэх;
  - *Уялдаа холбоо:* Төсөөлөн авч хэлэлцсэн нэмэлт мэдээлэл нь одоо байгаа тайланд нэгэнт тусган оруулсан мэдээлэлтэй нягт уялдаатай байх шаардлагатай эсэх. Зөвхөн шинэ ба одоо байгаа мэдээллийн уялдаа холбоог бус, харин бүх мэдээллийн хоорондох уялдаа холбоог үнэлэх шаардлагатай байдаг.
- 8.39 Одоо байгаа цогц мэдээлэлд нэмж мэдээлэл оруулах хэтийн төлөвөөр илэрхийлэгдэх дээрх хүчин зүйлсийг одоо байгаа мэдээллийн бүлэглэлийг сайжруулж болох эсэхийг авч үзэх үедээ мөн харгалзах бөгөөд мэдээллийн зохион байгуулалт хэсэгт энэ талаар авч хэлэлцэнэ.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТой  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

8.40 Дараах тохиолдолд тусдаа НЗСТ шаардлагатай байж болох юм:

- Одоо байгаа тайлангаар үл хангагдах хэрэглэгчдийн нэмэлт мэдээллийн хэрэгцээг тодорхойлох;
- Эдгээр хэрэгцээг хангах тусдаа НЗСТ нь одоо байгаа тайланд мэдээллийг тусган оруулах бус, харин санхүүгийн тайлагналын зорилтууд болон чанарын шинжүүдийг биелүүлэх илүү их магадлалтай бай.

**Тайланд мэдээллийг байршуулах зарчим**

8.41 Толилуулгын тохиромжтой арга зүй ашигласнаар тухайн тайлагнасан мэдээллийг ихэвчлэн илэрхийлдэг гэдгийг энэ Бүлгийн 8.17-р параграфт заасан. Байршил нь үүнийг гүйцэтгэх нэг арга зам юм. Тайлан дахь мэдээллийн байршил нь тухайн тайлагнасан мэдээлэлд зохих ач холбогдол өгсөн бөгөөд хэт нуршуу буюу хэт нүсэр тодруулга бүхий мэдээллээр утга санааг бүрхэгдүүлээгүй гэдгийг ханган магадалдаг.

8.42 Санхүүгийн тайлан дахь мэдээллийн байршил нь байгууллагын санхүүгийн ойлгомжтой дүр зургийг хүргэн танилцуулахад хувь нэмрээ оруулдаг.

8.43 Санхүүгийн тайлангийн хувьд, тайлагнасан мэдээллийг зохих тайлангийн дотор, харин тодруулгыг тэмдэглэл хэсэгт харуулдаг. Тайлагнасан мэдээлэл ба тодруулсан мэдээллийг байршлаар ялган зааглах нь байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ гэх мэт хүргэн танилцуулах асуудалтай шууд холбоотой зүйлсийг онлоцн харуулах, тэмдэглэл хэсэг дэх тодруулгаар дамжуулан илүү дэлгэрэнгүй мэдээллийг бүрдүүлэх эсэхийг ханган магадалдаг.

8.44 Бусад НЗСТ-гийн хувьд, тайлагнасан мэдээллийг тодруулсан мэдээллээс тусдаа байршуулж эсвэл тухайн талбарт байршуулж болох боловч тухайн тодруулсан мэдээллээс ялган зааглах ба толилуулгын өөр бусад арга зүй ашигласнаар зохих ач холбогдол өгдөг.

**Мэдээллийн зохион байгуулалт**

8.45 Мэдээллийн зохион байгуулалт нь мэдээллийн эмхлэн бүрдүүлэлт, бүлэглэлт, эрэмбэ дарааллыг авч үздэг бөгөөд үүнд дараах зүйлсийн талаархи шийдвэр хамаардаг:

- НЗСТ-д мэдээллийг хэрхэн эмхлэн бүрдүүлэх эсэх;
- НЗСТ-гийн ерөнхий бүтэц.

8.46 Мэдээллийн зохион байгуулалт нь өргөн хүрээтэй шийдвэрийг, үүн дотроо харилцан лавлагаа, хүснэгт, график, гарчиг, дугаарлалт ашиглах эсэх шийдвэр, тайлангийн тодорхой нэг бүрэлдэхүүн хэсгийн хүрээн дэх зүйлсийн эмхлэн бүрдүүлэлт, үүн дотроо зүйлсийн дэс дараалал тогтоох шийдвэрийг агуулсан байдаг. Мэдээллийг хэрхэн зохион байгуулах нь түүний талаархи хэрэглэгчдийн тайлбарт нөлөө үзүүлдэг.

### **Зохион байгуулалтанд хамаарах мэдээллийн шинж төрөл**

8.47 Мэдээллийн зохион байгуулалтын талаархи шийдвэрээр дараах зүйлсийг харгалздаг:

- Мэдээллийн хоорондох чухал уялдаа холбоо;
- Мэдээллийг тайлагнах эсвэл тодруулах эсэх.

#### *Уялдаа холбооны төрлүүд*

8.48 Чухал уялдаа холбоонд дараах зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:

- Сайжруулалт;
- Адил төстэй байдал;
- Хамтын зорилго.

8.49 Сайжруулалт: НЗСТ-гийн аль нэг хэсэг дэх мэдээллийг өөр хэсэгт харуулсан мэдээллээр сайжруулж болох юм. Жишээлбэл; төсөв, хэтийн болон үйлчилгээний гүйцэтгэлийн талаархи мэдээлэл нь санхүүгийн тайлан дахь мэдээллийг сайжруулан тодотгодог. Хүүрнэсэн мэдээллийн ойлгомжтой байдлыг сайжруулахын тулд хүснэгт, график ашиглаж болох юм. НЗСТ-гаас гадуур тайлагнасан мэдээлэлтэй уялдуулан холболт нь НЗСТ-д тайлагнасан мэдээллийн ойлгомжтой байдлыг сайжруулж болох юм.

8.50 Адил төстэй байдал: НЗСТ-гийн аль нэг хэсэг тайлагнасан мэдээлэл нь түүний өөр нэг хэсэгт тайлагнасан мэдээлэлд үндэслэдэг бөгөөд уг мэдээлэлд тохируулга хийгээгүй буюу харьцангуй жижиг тохируулга хийсэн тохиолдолд адил төстэй байдлын уялдаа холбоо оршин байдаг. Жишээлбэл; үйлчилгээний гүйцэтгэлийн мэдээлэл нь үйлчилгээний өртөг болон янз бүрийн үйлчилгээнд ашигласан хөрөнгийн үнэ цэнийг агуулдаг бол тэдгээр нийт дүн нь санхүүгийн тайланд тайлагнасан зардал ба хөрөнгөтэй хэрхэн уялдаж байгааг харуулах нь ач холбогдолтой байж болно. Өөр нэг жишээ нь; тайлагнасан нийт зардал ба төсвийн хоорондох уялдаа холбоо, тайлагнасан нийт зардал ба санхүүгийн үр дүнгийн тайланд тайлагнасан нийт зардлын хоорондох уялдаа холбоо юм. Хоёр өөр дүнгийн хоорондох тохируулга нь байгууллагын санхүүгийн талаархи хэрэглэгчдийн ойлголтыг нэмэгдүүлж болох юм.

8.51 Хамтын зорилго: Өөр өөр хэсэгт тайлагнасан мэдээлэл нь тухайн нэг зорилгод хувь нэмрээ оруулдаг тохиолдолд хамтын зорилгын уялдаа холбоо оршин байдаг. Жишээлбэл; өөр өөр тайлан ба тодруулга нь үзүүлсэн үйлчилгээний хариуцлагын үнэлгээнд шаардлагатай мэдээллээр хангадаг тохиолдол юм. (а) Янз бүрийн үйлчилгээний бодит ба төсөвлөсөн өртөг, (б) янз бүрийн үйлчилгээ үзүүлэхэд ашигласан санхүүгийн болон санхүүгийн бус нөөц, (в) ирээдүйд үзүүлэх янз бүрийн үйлчилгээний талаархи мэдээллийг тайлангийн өөр өөр хэсэгт тусган оруулж болно. Өөр

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

өөр байршил дахь мэдээллийн хоорондох уялдаа холбоог тодорхой болгохын тулд нийтлэг гарчиг, харилцан лавлагаа гэх мэт арга зүйг ашигласнаар мэдээллийг зохион байгуулах нь тохиромжтой байж болно.

8.52 Дараах өөр өөр байршил дахь мэдээллүүдийн хооронд уялдаа холбоо оршин байж болно:

- НЗСТ;
- НЗСТ-гийн бүрэлдэхүүн хэсгүүд;
- Нэг бүрэлдэхүүнийн доторх хэсгүүд.

*Мэдээллийн бүлэглэлт*

8.53 Мэдээллийн байршлын талаархи шийдвэрт хамаарах гурван хүчин зүйлсийг мэдээллийн сонголт гэсэн хэсэгт тэмдэглэсэн. Үүнд: уялдаа холбоо, мэдээллийн шинж төрөл, улс орны тусгайлсан шинж гэсэн хүчин зүйлс хамаарна. Одоо байгаа мэдээллийн бүлэглэлтийг сайжруулж болох эсэхийг авч үзэхдээ эдгээр хүчин зүйлсийг мөн харгалздаг.

**Мэдээллийн зохион байгуулалтанд мөрдөх зарчим**

8.54 Мэдээллийн зохион байгуулалт нь:

- Санхүүгийн тайлагналын зорилтуудыг биелүүлэхэд дэмжлэг үзүүлдэг;
- Тайлагнасан мэдээлэл нь чанарын шинжүүдийг хангахад туслалцаа үзүүлдэг.

8.55 Мэдээллийн зохион байгуулалт нь:

- Гол утга санаа ойлгомжтой эсэхийг ханган магадлахад тусалдаг;
- Чухал харилцаа холбоог оновчтой тодорхойлдог;
- Гол утга санааг илэрхийлэх мэдээлэлд зохих ач холбогдол өгдөг;
- Зэрэгцүүлэлт хийхэд тусалдаг.

8.56 Зохих гарчиг, толилуулгын эрэмбэ дараалал ба/буюу тухайн мэдээллийн уялдаа холбоо болон төрөлд тохиромжтой бусад аргуудыг ашигласнаар холбогдох мэдээллийг уялдуулдаг. Уялдаа холбоо нь НЗСТ-гаас гадуур тайлагнасан мэдээлэлд хамааралтай тохиолдолд дараах зүйлс чухал ач холбогдолтой юм. Үүнд:

- Бусад эх сурвалжаас авсан мэдээлэлтэй холбогдох уялдаа холбоо нь НЗСТ-гийн чанарын шинжүүдийн биелэлтийг алдагдуулахгүй байх;
- Тайлагнасан мэдээлэл нь цаг хугацаандаа байхын тулд ийм аливаа уялдаа холбоотой мэдээллийн гаргалтын өдөр нь тухайн санхүүгийн тайлангийн тайлагналын өдөртэй аль болох ойрхон байх.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

*Зэрэгцүүлэгдэх боломжтой байх*

8.57 Мэдээллийн зохион байгуулалт нь цаг хугацааны явц дахь тууштай толилуулгын үр өгөөжийг харгалздаг. Тууштай толилуулга нь мэдээллийг ойлгох хэрэглэгчдийн чадвар боломжид дэмжлэг үзүүлж, мэдээлэлд тэднийг хандан нэвтрэхэд тусалдаг. Энэ нь мөн зэрэгцүүлэгдэх боломжтой байдал гэсэн чанарын шинжийг биелүүлэхэд тусалцаа үзүүлдэг.

*Санхүүгийн тайлангийн хүрээн дэх мэдээллийн зохион байгуулалтын зарчим*

8.58 Санхүүгийн тайланд тайлагнах мэдээллийг ихэвчлэн тоон нийт дүн ба дэд дүнгээр зохион байгуулдаг. Ийм зохион байгуулалт нь уг тайлагнагч байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ гэх мэт зүйлсийн талаархи бүтэцчилсэн ерөнхий тоймоор хангадаг.

8.59 Санхүүгийн тайлангийн хувьд дараах зүйлсийн хооронд уялдаа холбоо оршин байж болно:

- Тайлагнасан дүнгүүдийн дэд хэсгүүд буюу тайлагнасан дүнгүүдийн өөрчлөлт, түүнчлэн байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээнд тэдгээрийн үзүүлэх үр нөлөө;
- Өөр өөр санхүүгийн тайланд тайлагнасан янз бүрийн дүнгүүд, энэ бүгд нь гаднын нийтлэг үйл явдлын үр нөлөөг тусгах буюу тухайн байгууллагын санхүүгийн байдал эсвэл санхүүгийн үр дүнг ойлгоход хамтдаа хувь нэмэр оруулдаг;
- Тайлагнасан зүйлсийг тайлбарлах буюу тэдгээрийн талаархи хэрэглэгчдийн ойлголтонд өөр бусад байдлаар дэмжлэг үзүүлж болох мэдээллээр хангах тайлагнасан дүнгүүд болон холбогдох тэмдэглэл тодруулга.

8.60 Санхүүгийн тайлан дахь мэдээллийн зохион байгуулалт нь дараах зүйлсийн талаархи шийдвэрийг агуулдаг:

- Тайлангийн төрөл ба тоо;
- Нийт дүнг ач холбогдол бүхий дэд ангилалуудад салгаан задлалт;
- Тайлан бүрийн хүрээнд тайлагнасан зүйлсийн эрэмбэ дараалал ба бүлэглэлт;
- Нэгтгэн нийлүүлсэн дүнгүүдийн тайлбар тодорхойлолт (нэмэгдэх ба хасагдах);
- Тайланд тусган оруулах бусад мэдээллийн тайлбар тодорхойлолт.

8.61 Санхүүгийн тайланд тайлагнасан зүйлстэй холбогдох уялдаа холбоог тодорхой, ойлгомжтой болгох тийм байдлаар уг санхүүгийн тайлангийн тэмдэглэл хэсэгт тодруулсан мэдээллийг зохион байгуулдаг. Тэмдэглэл хэсэг нь уг санхүүгийн тайлангийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.

*Бусад НЗСТ-гийн хүрээнд мэдээллийг зохион байгуулах зарчим*

- 8.62 Санхүүгийн тайлангийн зохион байгуулалттай адилаар, бусад НЗСТ дахь мэдээллийн зохион байгуулалт нь уг тайлагнасан мэдээллээр илэрхийлэх гол утга санааны ойлгомжтой байдлыг хангахад тусалдаг. Чухал уялдаа холбоог тодорхой заан илэрхийлэх толилуулга нь уг тайлангийн дараах шаардлагыг хангах хэр хэмжээг сайжруулах магадлалтай байдаг:
- Санхүүгийн тайлагналын зорилтуудыг хангах;
  - Чанарын шинжүүдийг хангах.
- 8.63 Холбогдох мэдээллийг уялдуулан харуулах нь чухал мэдээллийг олж мэдэхэд хэрэглэгчдэд тусалдаг. Зарим мэдээллийг график, диаграм, хүснэгт, таблиц, харьцаа, гүйцэтгэлийн гол үзүүлэлт хэлбэрээр зохион байгуулах үед илүү ойлгомжтой болдог. Өөр бусад мэдээллийг хүүрнэсэн хэлбэрээр илүү үр дүнтэйгээр толилуулж болох юм. Мэдээллийн зохион байгуулалт нь тухайн нэг НЗСТ-гийн хүрээнд дэх мэдээллүүдийн хоорондох уялдаа холбоог хэрэглэгчид ойлгоход дэмжлэг үзүүлдэг.
- 8.64 Мэдээллийн зохион байгуулалт нь тухайн зүйлс ижил төсөөтэй эсвэл ижил төсөөгүй эсэхийг тодорхой болгох гэх мэт арга замаар зэрэгцүүлэлт хийхэд туслалцаа үзүүлдэг. Тухайн нэг байгууллагын хувьд мэдээллийг зохион байгуулах арга замыг нэг жилээс дараагийн жилд өөрчлөх нь мэдээллийн хамааралтай ба ойлгомжтой байдлыг сайжруулахаас бусад тохиолдолд ингэж өөрчлөхөөс зайлсхийх нь тайлант үе хоорондох зэрэгцүүлэгдэх байдалд дэмжлэг үзүүлдэг. Тайлагнагч янз бүрийн байгууллагууд нь мэдээллийг ижил төсөөтэй арга замаар тайлагнах байдлаар зохион байгуулах нь байгууллага хоорондох зэрэгцүүлэгдэх байдалд дэмжлэг үзүүлдэг.

## Дүгнэлтийн үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь Онолын Үзэл Баримтлалыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### НЗСТ дахь толилуулгад мөрдөх ойлголт ухагдахуун

ДҮ8.1. НЗСТ, үүн дотроо санхүүгийн тайлан болон тухайн санхүүгийн тайланг бэхжүүлэн сайжруулах, нэмж гүйцээх, дэлгэрүүлэн баяжуулах нэмэлт мэдээллийн аль алины хувьд мөрдөх ойлголт ухагдахууныг энэ Бүлэгт тайлбарласан. Энэ Бүлгийг боловсруулах явцад, “*Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлан дахь Толилуулга*” гэсэн Зөвлөлдөх Баримт Бичиг (Зөвлөлдөх Баримт Бичиг) болон “*Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлан дахь Толилуулга*” гэсэн Саналын Төсөлд хариулт ирүүлсэн зарим хүмүүс нь УСНББОУСЗ зөвхөн санхүүгийн тайланд голлон анхаарах хэрэгтэй гэж шүүмжилж байсан. Уг санал болгосон илүү дэлгэрэнгүй хандлагыг дэмжсэн, хариулт ирүүлсэн зарим хүмүүс нь санхүүгийн тайланд тусгайлан хамаарах асуудлуудыг харгалзахын тулд тэрхүү үр дүнгийн ойлголт ухагдахууныг мөн хангалттай дэлгэрэнгүй илэрхийлэх хэрэгтэй гэж үзсэн.

ДҮ8.2. Санхүүгийн тайлан ба бусад НЗСТ-гийн аль алин дахь мэдээллийн үр дүнтэй толилуулга нь санхүүгийн тайлагналын зорилтуудыг хангахад маш чухал гэж УСНББОУСЗ үзсэн. Бусад НЗСТ дахь мэдээллийн толилуулга нь УСНББОУСЗ болон тайлан бэлтгэгчдээс тодорхой анхаарал шаардах бөгөөд энэ нь УСНББОУС ба СБПУ-ийн аль алины толилуулгын шаардлага боловсруулахад чиглэл болох чухал ач холбогдолтой, зохих ойлголт ухагдахууныг хөгжүүлэхэд хүргэдэг. Гэвч санхүүгийн тайланд мөрдөхөд зориулан хангалттай нарийвчлан илэрхийлсэн ойлголт ухагдахуунаар хангах тийм хэрэгцээ шаардлагыг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Иймээс бүх НЗСТ-д зориулсан толилуулгын ойлголт ухагдахууныг энэ Бүлэгт тодорхойлж, санхүүгийн тайланд хамаарах ойлголт ухагдахууныг илүү гүнзгий авч үзсэн.

### Санхүүгийн тайлан дахь толилуулга

ДҮ8.3. Дээр дурдсанчлан, санхүүгийн тайлангаар ханган бүрдүүлэх цаашдын дэлгэрэнгүй мэдээлэл нь уг санал болгосон ойлголт ухагдахууныг санхүүгийн тайланд мөрдөх боломжтой эсэхийг ханган магадлах тийм хэрэгцээ шаардлагад хариулт өгдөг. Гэвч санхүүгийн тайлангийн тоо буюу төрлийг УСНББОУС болон СБПУ-д тусгайлан заах хэрэгтэй эсэхийг энэ Бүлэгт санал болгоогүй. Энэхүү хандлага нь бусад тайланг нэмж гаргах уян хатан зохицуулалтыг тайлан бэлтгэгч нарт олгохын хамтаар тайлан бэлтгэгч зарим хүмүүс “үндсэн” санхүүгийн тайланг хамгийн наад захын шаардлага гэж үзнэ гэдгийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн. Жишээлбэл; санхүүгийн тайлангаас гадна амлалт баталгаа буюу улсын секторын өрийг жагсаан харуулсан нэмэлт тайланг УСНББОУС-аар шаарддаг. Энэ нь Онолын үзэл баримтлалын түвшинд хэт тусгайлан тодорхойлохоос зайлсхийх тийм шаардлагатай мөн нийцэх юм.



УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТой  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

ДҮ8.4. Санхүүгийн тайланд, үүн дотроо тэмдэглэлд тусган оруулвал зохих мэдээллийн жагсаалтыг энэхүү Бүлэгт тодорхойлохыг эрмэлзээгүй болно. Энэ нь дараах гэх мэт талбарт өөрчлөлт гарахын хэрээр санхүүгийн тайланд хамаарах толилуулгын ойлголт ухагдахуун хамааралтай хэвээр байна гэсэн утгыг илэрхийлдэг:

- Санхүүгийн тайлагналын зорилтуудыг зохих ёсоор биелүүлэхэд шаардлагатай мэдээллийн төрөл;
- НЗСТ-д мэдээллийг толилуулахад бэлэн боломжтой байгаа мэдээллийн технологи;
- Санхүүгийн тайланд мэдээллийг нь толилуулах эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийн төрөл.

### **Санхүүгийн тайлан болон бусад НЗСТ-г бэлтгэн гаргасан хэл**

ДҮ8.5. Санхүүгийн тайлан болон бусад НЗСТ-г бэлтгэн гаргасан хэл (буюу хэлүүд) нь санхүүгийн тайлагналын зорилтууд ба чанарын шинжүүдийг хангахад дэмжлэг үзүүлнэ гэсэн байр суурийг Саналын Төсөлд хариулт ирүүлсэн зарим хүмүүс илэрхийлсэн. Энэхүү санаа зовж буй асуултанд хариулт өгөхийн тулд УСНББОУСЗ нь НЗСТ-г гаргадаг хэл (буюу хэлүүд)-ийг энэ Бүлэгт авч үзэх хэрэгтэй гэж шийдвэрлэсэн. Аливаа орчуулгын чанар нь тухайн орчуулгаас хамаарал бүхий хэрэглэгчдийн хувьд НЗСТ-гийн ач холбогдолтой байдалд нөлөө үзүүлдэг. Орчуулагдсан хувилбар (хувилбарууд) нь эх хэл дээрх хувилбарын үнэн зөв илэрхийлэл эсэхийг магадлахын тулд орчуулгын чанар хангалттай байвал зохино. Үнэн зөв оруулга нь эх хэл дээрх хувилбарыг уншиж буй тухайн эх хэл бүхий хэрэглэгчидтэй адил ойлголтыг бусад хэрэглэгчид авах боломж бүрдүүлдэг.

### **Толилуулга, тайлагнал, тодруулга**

ДҮ8.6. Энэхүү Бүлгийг боловсруулах явцад, “толилуулга”, “тайлагнал”, “тодруулга”, “гол чухал мэдээлэл”, “дэмжих мэдээлэл” гэсэн хэллэгийн тайлбар тодорхойлолтыг санал болгосон. Хариулт ирүүлсэн хүмүүс нь эдгээр тайлбар тодорхойлолт тохиромжтой эсэх талаар янз бүрийн байр суурийг илэрхийлсэн. Мэдээллийн сонголт, байршил, зохион байгуулалтыг агуулсан толилуулга гэсэн үгийн тайлбар тодорхойлолтыг маш их дэмжиж байсан. Хариулт ирүүлсэн зарим хүмүүс нь “толилуулга” ба “тодруулга” гэсэн нэр томъёог стандарт тогтоогч нар өргөнөөр ашигладаг бөгөөд нийтээр хүлээн зөвшөөрсөн утга агуулгатай гэж үзсэн учраас ийм тайлбар тодорхойлолт оруулахыг эсэргүүцсэн. Онолын Үзэл Баримтлалыг шинэчлэн баяжуулах өөрийн төслөөр Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс боловсруулж буй санхүүгийн тайлангийн толилуулгын нэр томъёотой УСНББОУСЗ-ийн нэр томъёог нийцүүлэхийг Саналын Төсөлд хариулт ирүүлсэн зарим хүмүүс дэмжиж байсан.

ДҮ8.7. Зөвхөн санхүүгийн тайланд бус, харин НЗСТ-д тусгасан бүх мэдээлэлд мөрдөх нэр томъёотой байх нь гагцхүү санхүүгийн тайланд хамаарах нэр

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

томъёотой бүрэн нийцэхгүй байж болно гэж УСНББОУСЗ үзсэн. Санхүүгийн тайлан дахь гол утга санааг илэрхийлэх мэдээлэлд “толилуулга” гэсэн нэр томъёог хэрэглэдэг бол НЗСТ-д тусгасан бусад мэдээлэлд уг нэр томъёог өргөжүүлэн ашиглах нь түүний утгыг өөрчлөхөд хүргэх юм. “Тайлагнах” гэсэн нэр томъёо нь гол утга санааг илэрхийлж буй мэдээллийг тухайн санхүүгийн тайлангийн хувьд, эсвэл НЗСТ-д тусгасан бусад мэдээллийн хувьд сонгох эсэхийг анхааруулан илэрхийлнэ.

ДҮ8.8. Толилуулга нь санхүүгийн тайланд мэдээллийг тайлагнах үйл явцыг, харин тодруулга нь санхүүгийн тайлангийн тэмдэглэлд мэдээллийг тайлагнах үйл явцыг илэрхийлэх байдлаар зарим улс оронд ашигладаг толилуулга ба тодруулгын хоорондох ялгаатай байдал нь НЗСТ-гийн толилуулгын ойлголт ухагдахууны хувьд тохиромжгүй гэж УСНББОУСЗ үзсэн. Санхүүгийн тайланд голлон чиглэсэн ийм ялгаатай байдал нь ач холбогдол багатай бөгөөд санхүүгийн тайлангаас гадуурх, бусад НЗСТ-гийн хувьд будлиан үүсэхэд хүргэж болох юм. Санхүүгийн тайлангийн хувьд, тайлагнал ба тодруулга гэсэн нэр томъёо нь тодорхой зааг ялгаа үүсгэж чадна. Тайлагнал нь санхүүгийн тайланд мэдээллийг тайлагнах үйл явц, харин тодруулга нь санхүүгийн тайлангийн тэмдэглэл хэсэгт мэдээллийг тайлагнах үйл явц юм. Эдгээр шалтгааны улмаас УСНББОУСЗ нь Саналын Төсөлд санал болгосон толилуулга, тайлагнал, тодруулга гэсэн хэллэгт хянан засварласан тайлбар оруулснаар хэвээр үлдээсэн.

ДҮ8.9. Зөвлөлдөх Баримт Бичигт санал болгосон толилуулгын тайлбар тодорхойлолт нь толилуулгын дараах хоёр утга санааны аль алиныг тусган агуулсан байдаг. Үүнд: толилуулга нь мэдээллийн сонголт, байршил, зохион байгуулалт юм; толилуулга нь санхүүгийн тайлагналын зорилтууд ба хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангаж, чанарын шинжүүдийг биелүүлдэг. Нарийвчлан авч үзсэний эцэст, УСНББОУСЗ нь эдгээр хоёр талбарыг салган заагласнаар толилуулгын асуудлуудын хэлэлцүүлэгт илүү сайн туслалцаа үзүүлнэ гэж шийдвэрлэсэн. Иймээс толилуулгыг мэдээллийн сонголт, байршил, зохион байгуулалт гэж тодорхойлдог. Толилуулгаар юунд хүрэхийг эрмэлздэг талаархи тайлбар тодорхойлолт бас байдаг бөгөөд толилуулга нь НЗСТ-д тусгасан мэдээллийн хязгаарлалтуудыг харгалзахын зэрэгцээгээр, тухайн санхүүгийн тайлагналын зорилтуудад хувь нэмрээ оруулах ба чанарын шинжүүдийг биелүүлэх тийм мэдээллээр хангадаг.

ДҮ8.10. Зөвлөлдөх Баримт Бичигт санал болгосончлон, гол чухал ба дэмжих мэдээллийг хооронд нь ялган тодорхойлсноор санхүүгийн тайлангийн тэмдэглэл дэх мэдээлэл нь санхүүгийн тайлан дахь мэдээллээс ач холбогдол багатай гэсэн утгатай болох бөгөөд ингэснээр эрэмбэ шатлал үүсгэнэ гэж хариулт ирүүлсэн зарим хүмүүс үзэж байсан. Дэмжих мэдээлэл нь гол чухал мэдээллээс ач холбогдол багатай гэсэн утгыг илэрхийлэх санаа зорилгогүй байсан боловч УСНББОУСЗ нь энэ үндэслэлийг хүлээн зөвшөөрсөн. Иймээс УСНББОУСЗ нь гол чухал ба дэмжих мэдээллийг хооронд нь ялган тодорхойлох шаардлагатай эсэхийг дахин харгалзан үзсэн бөгөөд НЗСТ тус бүрийн хүрэн дэх тайлагнал ба тодруулгын тайлбар тодорхойлолтод энэхүү мэдээллийн хоёр төрөлтэй холбоотой утга

## УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

санааг тусган оруулах нь илүү тохиромжтой гэж дүгнэсэн. Иймээс гол чухал мэдээлэл ба дэмжих мэдээлэл гэсэн нэр томъёог Саналын Төслөөс хассан бөгөөд нэг төрлийн мэдээлэл нь нөгөө төрлийн мэдээллээс илүү чухал ач холбогдолтой гэсэн утга илэрхийлэхгүй, харин ямар төрлийн мэдээллийг тайлагнах, ямар төрлийн мэдээллийг тодруулах эсэхийг тайлбарлахын тулд тайлагнал ба тодруулгын тайлбар тодорхойлолтыг хянан засварласан. Уг арга хандлагыг энэ Бүлэгт авч хэлэлцсэн.

ДҮ8.11. Бүх НЗСТ нь тайлагнах мэдээлэл ба тодруулах мэдээллийн аль алиныг агуулдаг эсэх, түүнчлэн НЗСТ нь зөвхөн тодруулах мэдээллийг агуулсан байх боломжтой эсэхийг УСНББОУСЗ мөн харгалзан үзсэн. НЗСТ-гийн төрөл тус бүрийн хувьд гол утга санаа оршин байдаг бөгөөд тэрхүү гол утга санааг илэрхийлэх мэдээллийг тайлагнах шаардлагатай учраас бүх НЗСТ нь тайлагнах мэдээлэл ба тодруулах мэдээллийн аль алиныг агуулна гэж УСНББОУСЗ дүгнэсэн.

### **Толилуулгын ерөнхий хандлага**

ДҮ8.12. Доорх байдлаар толилуулах арга хандлагыг Зөвлөлдөх Баримт Бичигт санал болгосон:

- Толилуулгын зорилтуудыг тодорхойлохын тулд хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад голлон чиглэх;
- Толилуулгын талаархи шийдвэрт чанарын шинжүүдийг харгалзан хэрэглэх;
- Толилуулгын тусдаа ойлголт ухагдахууныг олж тогтоох – уг санал болгосон ойлголт ухагдахуун дараах байдалтай байна. Үүнд: Ойлголт ухагдахуун 1: Хэрэглэгчийн хэрэгцээг хангах, өртөг-өгөөжийн шалгуурыг биелүүлэх ба цаг хугацаандаа байх тийм мэдээллийг сонгох; Ойлголт ухагдахуун 2: Хэрэглэгчийн хэрэгцээг хангах байдлаар мэдээллийг байршуулах; Ойлголт ухагдахуун 3: Чухал уялдаа холбоог тодорхой харуулах ба зэрэгцүүлэгдэх боломжтой байдлыг дэмжихийн тулд мэдээллийг зохион байгуулах.

Тухайн тодорхой тайлан буюу тайлангийн агуулгын хүрээнд хэрэглэхийн тулд толилуулгын зорилтуудыг стандартын түвшинд тогтоох хэрэгтэй гэдгийг Зөвлөлдөх Баримт Бичигт мөн санал болгосон.

ДҮ8.13. Хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага ба чанарын шинжүүдийн биелэлт нь толилуулгын шийдвэрийн хувьд чухал ач холбогдолтой гэдгийг хариулт ирүүлсэн хүмүүс ерөнхийдөө хүлээн зөвшөөрсөн. Тэдгээр хүмүүс нь толилуулгын зорилтуудын боловсруулалтыг дэмжсэн боловч ийм зорилтуудыг зөвхөн стандартын түвшинд бус, харин Онолын үзэл баримтлалд тусгах хэрэгтэй гэж үзсэн. Хэдийгээр тэд толилуулгын тусдаа ойлголт ухагдахууныг боловсруулах хэрэгтэй гэдгийг ерөнхийдөө зөвшөөрсөн боловч хариулт ирүүлсэн маш олон хүмүүс нь уг санал болгосон толилуулгын гурван ойлголт ухагдахуунтай санал нийлэхгүй байсан. Хариулт ирүүлсэн зарим хүмүүс нь толилуулгын тэрхүү гурван

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

ойлголт ухагдахуунаар тодорхой чанарын шинжүүд буюу НЗСТ-д тусгасан мэдээллийн хязгаарлалтыг онцлон илэрхийлэх арга замтай санал нийлэхгүй байсан. Тэд бусад чанарын шинжүүд эсвэл хязгаарлалтуудыг авч үзэх хэрэгтэй гэж үзэж байсан. Өөр зарим хүмүүс нь Бүлэг 3, *Чанарын Шинжүүд* дэх чанарын шинжүүд болон НЗСТ-д тусгасан мэдээллийн хязгаарлалтуудын талаархи хэлэлцүүлэгт эдгээр ойлголт ухагдахуун ямар нэг зүйлийг нэмлээ гэхэд багахан зүйл байна гэж үзэж байсан.

ДҮ8.14. Бүлэг 1-4-д авч хэлэлцсэн, ойлголт ухагдахууныг толилуулгын шийдвэрт шууд мөрдөх арай хялбар бөгөөд илүү чиглэгдсэн хандлага тохиромжтой гэж УСНББОУСЗ эцэст нь дүгнэсэн. УСНББОУСЗ нь эдийн засгийн болон бусад юмс үзэгдлийн хувьд хэрэглэгчдийн мэдээллийн хэрэгцээг хангахын тулд мэдээллийн сонголт, байршил, зохион байгуулалтын талаар шийдвэр гаргах хэрэгтэй гэж үзсэн. Санхүүгийн тайлагналын зорилтуудыг биелүүлэхийн тулд толилуулгын шийдвэр гаргадаг бөгөөд үүнд чанарын шинжүүд болон НЗСТ-д тусгасан мэдээллийн хязгаарлалтуудыг харгалздаг.

ДҮ8.15. Толилуулгын шийдвэр нь дараах шинжтэй шийдвэр байж болно. Үүнд: (а) шинэ тайлан боловсруулах, тайлангуудын хооронд мэдээллийг шилжүүлэх, эсвэл одоо байгаа тайлангуудыг нэгтгэхэд хүргэж болох шийдвэр; эсвэл (б) тайлан доторх мэдээлэлтэй холбоотойгоор мэдээллийн сонголт, байршил, зохион байгуулалтын талаар гаргах дэлгэрэнгүй шийдвэр. Бүлэг 2-т авч хэлэлцсэн, санхүүгийн тайлагналын илүү дэлгэрэнгүй цар хүрээний хувьд толилуулгын энэхүү хоёр төрлийн шийдвэрийг ялган зааглах нь ач холбогдолтой байдаг. Хоёр төрлийн шийдвэрийн аль аль нь чухал ач холбогдолтой бөгөөд эрэмбэ шатлал тогтоох санаа зорилгогүй юм. Шийдвэрийн өргөн хүрээ буюу дэс дараалал нь эдгээрийн нэг ялгаатай тал юм. Жишээлбэл; шинэ тайлан гаргах шийдвэр нь илүү өргөн хүрээний мэдээллийг толилуулахад хүргэнэ. Үүний дараагийн илүү тусгайлсан шийдвэр нь тухайн тайланд ямар мэдээлэл толилуулахыг авч үздэг бөгөөд мөн адил ач холбогдолтой юм.

ДҮ8.16. Тайлагнах ба тодруулах мэдээллийг ялган зааглах шаардлага нь УСНББОУСЗ-ийн толилуулгын ерөнхий хандлагын цаашдын чухал ач холбогдолтой төлөв байдал юм. Тайлангийн хүрээн дэх нарийвчилсан шийдвэрийн жишээ нь; мэдээллийг санхүүгийн тайланд тайлагнах эсвэл тэмдэглэлд тодруулах хэрэгтэй эсэх талаархи шийдвэр юм.

#### *Толилуулгын зорилтууд*

ДҮ8.17. Дээр дурдсанчлан, толилуулгын шийдвэрүүдийн удирдамж чиглэл болох “толилуулгын зорилтууд” боловсруулахыг УСНББОУСЗ нь Зөвлөлдөх Баримт Бичигт санал болгосон. Хариулт ирүүлсэн олон хүмүүс нь толилуулгын зорилтуудыг тодорхойлохыг дэмжсэн боловч ингэж оруулах нь Бүлэг 2-т заасан, санхүүгийн тайлагналын зорилтуудын хүрээнд толилуулгын шаардлагагүй нэмэлт давхаргыг үүсгэх учраас УСНББОУСЗ нь толилуулгын зорилтуудыг энэ Бүлэгт оруулахгүй байхаар шийдвэрлэсэн. Толилуулгын зорилтуудын хоёр давхарга үүсгэлт нь

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

будлиан үүсгэх ба санхүүгийн тайлагналын зорилтуудаас гажихад хүргэж болох юм. Саналын Төсөлд энэхүү хандлагыг санал болгосон бөгөөд хариулт ирүүлсэн хүмүүс ерөнхийдөө дэмжсэн.

*Чанарын шинжүүд болон хязгаарлалтуудын мөрдөлт*

ДҮ8.18. Энэ Бүлгийг боловсруулах явцад хариулт ирүүлсэн олон хүмүүс нь толилуулгын шийдвэрт чанарын шинжүүд ашиглахыг дэмжсэн. Гэвч хариулт ирүүлсэн зарим хүмүүс нь НЗСТ-д тусгасан мэдээллийн хязгаарлалтыг толилуулгын ерөнхий хандлагад зохих ёсоор нэгтгэн оруулаагүй гэж эргэлзэж буйгаа илэрхийлсэн. Хязгаарлалтуудыг толилуулгын шийдвэрт мөрдөхийг УСНББОУСЗ зөвшөөрсөн. Иймээс эдгээрийг толилуулгын ерөнхий хандлагад болон толилуулгын гурван шийдвэрийг ашиглах талаархи дараагийн хэлэлцүүлэгт тусган оруулсан.

*Толилуулгын ойлголт ухагдахуун*

ДҮ8.19. Зөвлөлдөх Баримт Бичигт санал болгосон, толилуулгын гурван ойлголт ухагдахууны талаархи хариулт ирүүлсэн хүмүүсийн санал бодол, түүнчлэн тэдгээр санал бодлыг харгалзах цаашдын боломжит өөрчлөлтийг авч үзсэний дараа УСНББОУСЗ нь чанарын шинжүүд болон НЗСТ-д тусгасан мэдээллийн хязгаарлалтуудыг толилуулгын шийдвэрт мөрдсөнөөр энэхүү гурван ойлголт ухагдахууны утга санааг зохих ёсоор илэрхийлнэ гэж дүгнэсэн. Иймээс Зөвлөлдөх Баримт Бичигт санал болгосон толилуулгын гурван ойлголт ухагдахууныг УСНББОУСЗ нь чанарын шинжүүд болон НЗСТ-д тусгасан мэдээллийн хязгаарлалтуудыг толилуулгын шийдвэрт мөрдөх талаархи хянан засварласан тайлбар тодорхойлолтоор сольж, Саналын Төсөлд оруулсан. Саналын Төсөлд хариулт ирүүлсэн хүмүүс нь завсрын цогц толилуулгын ойлголт ухагдахуун эсвэл толилуулгын зорилтуудыг боловсруулахын оронд Бүлэг 1-4-т авч хэлэлцсэн, ойлголт ухагдахууныг шууд мөрдөхийг ерөнхийдөө дэмжсэн.

**Мэдээллийн зохион байгуулалт: Гаднын мэдээлэлтэй холбогдох уялдаа холбоо**

ДҮ8.20. НЗСТ-гийн хэрэглэгчид нь бусад эх сурвалжаас авсан мэдээллийг, үүн дотроо одоогийн болон урьдчилан таамагласан эдийн засгийн нөхцөл байдал, төсөв, прогнозын талаархи тайлан, түүнчлэн НЗСТ-д тусгадаггүй засгийн газрын бодлогын санаачлагын талаархи мэдээллийг мөн харгалзан үзэх шаардлагатай байж болно гэдгийг Онолын үзэл баримтлалын Бүлэг 2-т тайлбарласан. НЗСТ нь ийм мэдээлэлтэй уялдаа холбоотой байх хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн. Ийм мэдээлэл нь чанарын шинжүүдийг биелүүлэхгүй байх эрсдлийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн боловч тухайн уялдаа холбоо нь ойлгомжтой байдалд дэмжлэг үзүүлнэ гэж дүгнэсэн. Иймээс гадаад эх сурвалжаас авсан мэдээлэл нь чанарын шинжүүдийн биелэлтийг сулруулахгүй бол НЗСТ нь ийм мэдээлэлтэй холбогдох уялдаа холбоог агуулсан байж болно гэж УСНББОУСЗ дүгнэсэн.

УЛСЫН СЕКТОРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ЗОРИЛГОТОЙ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Гарчиг	Гаргасан огноо	Зөвлөлдөх хугацааны дуусгавар болголт
Зөвлөлдөх Баримт Бичиг, “Санхүүгийн Тайлагналын Зорилтууд”; “Санхүүгийн Тайлагналын Цар Хүрээ”; “Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайланд Тусгасан Мэдээллийн Чанарын Шинжүүд”; “Тайлагнагч Байгууллага”	2008 оны 9 дүгээр сарын 30	2009 оны 3 дугаар сарын 30
Зөвлөлдөх Баримт Бичиг, “Элементүүд ба Санхүүгийн Тайлан дахь Хүлээн Зөвшөөрөлт”	2010 оны 12 дугаар сарын 15	2011 оны 6 дугаар сарын 14
Зөвлөлдөх Баримт Бичиг, “Санхүүгийн Тайлан дахь Хөрөнгө, Өр Төлбөрийн Хэмжилт”	2010 оны 12 дугаар сарын 15	2011 оны 6 дугаар сарын 14
Саналын Төсөл 1, “Үүрэг, Бүрэн эрх ба Цар хүрээ; Зорилтууд ба Хэрэглэгчид; Чанарын Шинжүүд; Тайлагнагч Байгууллага”	2010 оны 12 дугаар сарын 15	2011 оны 6 дугаар сарын 14
Саналын Төсөл, “Санхүүгийн Тайлагналд Боломжит Нөлөө Бүхий Улсын Секторын Гол Шинжүүд”	2011 оны 4 дүгээр сарын 29	2011 оны 8 дугаар сарын 31
Зөвлөлдөх Баримт Бичиг, “Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлан дахь Топилуулга”	2012 оны 01 дүгээр сарын 29	2012 оны 5 дугаар сарын 31
Саналын Төсөл 2, “Элементүүд ба Санхүүгийн Тайлан дахь Хүлээн Зөвшөөрөлт”	2012 оны 11 дүгээр сарын 07	2013 оны 4 дүгээр сарын 30
Саналын Төсөл 3, “Санхүүгийн Тайлан дахь Хөрөнгө, Өр Төлбөрийн Хэмжилт”	2012 оны 11 дүгээр сарын 07	2013 оны 4 дүгээр сарын 30
Саналын Төсөл 4, “Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлан дахь Топилуулга”	2013 оны 4 дүгээр сарын 17	2013 оны 8 дугаар сарын 15

## УСНББОУС 1-САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЛИЛУУЛГА

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) 1, *Санхүүгийн Тайлангийн Толилуулга* (2003 онд хянан засварласан)-аас үндсэндээ бэлтгэсэн болно. НББОУС 1-ээс авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон ЕС4М 6ХН, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)

Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.

## УСНББОУС 1-САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЛИЛУУЛГА

### УСНББОУС-ын түүх

Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

УСНББОУС 1, Санхүүгийн Тайлангийн Толилуулга-ыг 2000 оны 5 дугаар сард гаргасан.

2006 оны 12 дугаар сард УСНББОУСЗ нь хянан засварласан УСНББОУС 1-ийг гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 1-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл (2017 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 39, Ажилтны Тэтгэмж (2016 оны 7 дугаар сард гаргасан)
- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 38, Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцооны Тодруулга (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 35, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2014-ийн Сайжруулалтууд (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2011-ийн Сайжруулалтууд (2011 оны 10 дугаар сард гаргасан)
- УСНББОУС-ын Сайжруулалтууд (2010 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 28, Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга (2010 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба Хэмжилт (2010 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 30, Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга (2010 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС-ын Сайжруулалтууд (2010 оны 11 дүгээр сард гаргасан)



**УСНББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт**

<b>Өөрчлөгдсөн параграф</b>	<b>Хэрхэн өөрчилсөн</b>	<b>Юугаар өөрчилсөн</b>
Танилцуулга хэсэг	Хассан	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
4	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
5	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
6	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
7	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
7А	Шинэ	УСНББОУС 28, 2010 оны 01-р сар
12	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
21	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2015 оны 01-р сар
29	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
44	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
53	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2015 оны 01-р сар
53А	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2015 оны 01-р сар
54	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2015 оны 01-р сар
70	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
73	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
74	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
75	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 30, 2010 оны 01-р сар
79	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 29, 2010 оны 01-р сар УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар
80	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
82	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 29, 2010 оны 01-р сар УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЛИЛУУЛГА

88	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
95	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
95А	Шинэ	УСНББОУС 28, 2010 оны 01-р сар
97	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
101	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 29, 2010 оны 01-р сар
103	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
109	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
116	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 39, 2016 оны 7-р сар УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
118	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
129	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 30, 2010 оны 01-р сар
134	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 38, 2015 оны 01-р сар
135	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
139	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 38, 2015 оны 01-р сар
148	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 30, 2010 оны 01-р сар
148А	Шинэ	УСНББОУС 30, 2010 оны 01-р сар
148Б	Шинэ	УСНББОУС 30, 2010 оны 01-р сар
148В	Шинэ	УСНББОУС 30, 2010 оны 01-р сар
148Г	Шинэ	УСНББОУС 28, 2010 оны 01-р сар
150	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 28, 2010 оны 01-р сар
151	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
152	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
153А	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар
153Б	Шинэ	УСНББОУС 28, 2010 оны 01-р сар
153В	Шинэ	УСНББОУС 30, 2010 оны 01-р сар
153Г	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
153Д	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2015 оны 01-р сар
153Е	Шинэ	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЛИЛУУЛГА

153Ж	Шинэ	УСНББОУС 38, 2015 оны 01-р сар УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
153И	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
153К	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
153Л	Шинэ	УСНББОУС 39, 2016 оны 7-р сар
153М	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
154	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар

2006 оны 12 дугаар сар

**УСНББОУС 1–САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЛИЛУУЛГА**

**АГУУЛГА**

	Параграф
Зорилго	1
Цар хүрээ	2-6
Тодорхойлолт	7-14
Эдийн засгийн нэгдмэл байгууллага	8-10
Ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи	11
Улсын Үйлдвэрийн Газар	12
Материаллаг байдал	13
Цэвэр хөрөнгө/Өмч	14
Санхүүгийн тайлангийн зорилго	15-18
Санхүүгийн тайлангийн хувьд хүлээх хариуцлага	19-20
Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгүүд	21-26
Ерөнхий шинжүүд	27-58
Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцсэн байдал	27-37
Тасралтгүй байх суурь	38-41
Толилуулгын тууштай байдал	42-44
Материаллаг байдал ба нэгтгэн нийлүүлэлт	45-47
Цэвэр дүн гаргах	48-52
Зэрэгцүүлэгдэх мэдээлэл	53-58
Бүтэц ба агуулга	59-150
Танилцуулга	59-60
Санхүүгийн тайлангийн ялган тодорхойлолт	61-65
Тайлант үе	66-68
Цаг хугацаандаа байх	69
Санхүүгийн байдлын тайлан	70-98
Эргэлтийн/эргэлтийн бус ангиллын ялгаа	70-75
Эргэлтийн хөрөнгө	76-79
Богино хугацаат өр төлбөр	80-87
Санхүүгийн байдлын тайланд толилуулах мэдээлэл	88-92
Санхүүгийн байдлын тайланд эсвэл тодруулгад толилуулах мэдээлэл	93-98
Санхүүгийн үр дүнгийн тайлан	99-117
Тайлант үеийн ашиг, алдагдал	99-101
Санхүүгийн үр дүнгийн тайланд толилуулах мэдээлэл	102-105
Санхүүгийн үр дүнгийн тайланд эсвэл тодруулгад толилуулах мэдээлэл	106-117
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	118-125
Мөнгөн гүйлгээний тайлан	126
Тодруулга	127-150
Бүтэц	127-131
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулга	132-139

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЛИЛУУЛГА

Тооцооллын тодорхойгүй байдлын гол эх сурвалж	140-148
Капитал	148А-148В
Цэвэр хөрөнгө/өмч гэж ангилсан, Буцаах эрхтэй санхүүгийн хэрэглүүр	148Г
Бусад тодруулга	149-150
Шилжилтийн нөхцөл	151-152
Хүчин төгөлдөр болох хугацаа	153-154
УСНББОУС 1 (2000)-ээс татгалзах	155
Хавсралт А: Санхүүгийн тайлагналын чанарын шинжүүд	
Хавсралт Б: Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт	
Дүгнэлтийн үндэслэл	
Хэрэгжүүлэх заавар удирдамж	
НББОУС 1-тэй харьцуулалт	

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЛИЛУУЛГА

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 1, *Санхүүгийн Тайлангийн Толилуулга*-ыг 1-155-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 1-ийг түүний зорилгын агуулга, Дүгнэлтийн Үндэслэл, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

1. Энэ Стандартын зорилго нь тухайн байгууллагын өмнөх тайлант үеүдийн санхүүгийн тайлантай, түүнчлэн өөр бусад байгууллагуудын санхүүгийн тайлантай зэрэгцүүлэх боломжтой байдлаар нийтлэг зорилготой санхүүгийн тайланг бэлтгэж толилуулах арга замыг тодорхойлоход оршино. Уг зорилгод хүрэхийн тулд энэхүү Стандарт нь санхүүгийн тайлангийн толилуулгын ерөнхий шинжүүд, түүнчлэн нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу бэлтгэх санхүүгийн тайлангийн бүтэц ба түүний агуулгын хамгийн наад захын шаардлагуудын талаархи заавар удирдамжийг тогтоодог. Тодорхой ажил гүйлгээ ба бусад үйл явдлын хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, тодруулгыг бусад УСНББОУС-д авч үзсэн.

## Цар хүрээ

2. **УСНББОУС-д нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бэлтгэж, толилуулах нийтлэг зорилготой бүх санхүүгийн тайланд энэхүү Стандартыг мөрдөнө.**
3. Нийтлэг зорилготой санхүүгийн тайлан гэдэг нь өөрсдийн тодорхой нэг мэдээллийн хэрэгцээнд зориулсан тайлан бэлтгэхийг шаардах тийм байр суурьтай байдаггүй хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэсэн санхүүгийн тайлан юм. Нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн хэрэглэгчид нь татвар төлөгчид, үнэ тариф тогтоогчид, хууль тогтоох байгууллагын ажилтнууд, зээлдүүлэгчид, бэлтгэн нийлүүлэгчид, хэвлэл мэдээллийнхэн болон ажиллагчид юм. Нийтлэг зорилготой санхүүгийн тайлан нь жилийн тайлан илтгэл гэх мэт нийтийн зориулалттай бусад баримт бичгийн бүрэлдэхүүнд оруулан эсвэл тусад нь толилуулдаг санхүүгийн тайланг агуулсан байна. Завсрын үеийн хураангуй санхүүгийн мэдээлэлд энэ Стандартыг мөрдөхгүй.
4. Энэхүү Стандартыг бүх байгууллагууд, үүн дотроо УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*-гийн дагуу нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэдэг, мөн УСНББОУС 34, *Тусдаа Санхүүгийн Тайлан*-гийн дагуу тусдаа санхүүгийн тайлан бэлтгэж толилуулдаг байгууллагууд мөн нэгэн адил дагаж мөрдөнө.
5. [Хассан]
6. [Хассан]

## Тодорхойлолт

7. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

**Аккруэл суурь** гэдэг нь ажил гүйлгээ ба үйл явдлыг тэдгээрийн гарч тохиолдсон үед (зөвхөн мөнгө буюу түүнтэй адилтгах хөрөнгийг хүлээн авсан буюу төлсөн үед биш) хүлээн зөвшөөрөх нягтлан бодох

бүртгэлийн суурь юм. Иймээс ажил гүйлгээ ба үйл явдлыг тэдгээрийн хамаарах тайлант үед нягтлан бодох бүртгэлд бүртгэж, санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрдөг. Аккруэл нягтлан бодох бүртгэлийн дагуу хүлээн зөвшөөрдөг элементүүд нь хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч, орлого, зардал юм.

Хөрөнгө гэдэг нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд байгууллага хяналтандаа оруулсан бөгөөд түүнээс уг байгууллагад ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бий болохоор хүлээгдэж буй нөөц юм.

Эздийн оруулсан хувь оролцоо гэдэг нь гаднын талуудаас тухайн байгууллагад өр төлбөр үүсгэхээс бусад байдлаар түүнд оруулсан ба уг байгууллагын цэвэр хөрөнгө/өмч дэх санхүүгийн хувь оролцоог тогтоодог, ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи юм. Энэ нь:

- (а) дараах зүйлсийн аль алианаас авах эрхийг олгодог: (i) тухайн эзэд буюу тэдний төлөөлөгчдийн саналаар, уг байгууллага өөрийн үйл ажиллагааны явцад хийх ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн хуваарилалт, (ii) уг байгууллага татан буугдах тохиолдолд түүний өр төлбөрөөс давсан аливаа хөрөнгийн хуваарилалт; ба/буюу
- (б) борлуулах, солилцох, шилжүүлэх буюу эргэлтээс гаргах боломжтой байна.

Эздэд олгосон хуваарилалт гэдэг нь тухайн байгууллага өөрийн бүх буюу зарим эздэд хөрөнгө оруулалтын өгөөж эсвэл хөрөнгө оруулалтын буцаалт хэлбэрээр хуваарилсан ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи юм.

Эдийн засгийн нэгдмэл байгууллага гэдэг нь хяналт тавигч байгууллага ба түүний хяналтанд буй байгууллагууд юм.

Зардал гэдэг нь эздэд олгосон хуваарилалттай холбоотойгоос бусад байдлаар цэвэр хөрөнгө/өмчийг багасгах үр дүн бүхий хөрөнгийн зарлагын гүйлгээ буюу хорогдон багасалт, эсвэл өр төлбөр үүсэлт хэлбэрээр тухайн тайлант үед үүссэн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн бууралт юм.

Шаардлагыг даган мөрдөх практик боломжгүй байдал гэдэг нь хэрэгжүүлэх ул үндэслэлтэй бүх хүчин чармайлтыг тухайн байгууллага гаргасан боловч даган мөрдөж чадаагүй нөхцөл байдал юм.

Өр төлбөр гэдэг нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн уг байгууллагын одоогийн үүрэг бөгөөд түүнийг барагдуулсанаар эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөц тухайн байгууллагаас гарахаар хүлээгдэж байдаг.



**Материаллаг байдал** Тухайн зүйлийн орхигдуулалт буюу буруу илэрхийлэлт нь уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн шийдвэр, хяналт үнэлгээнд дангаараа эсвэл хамтдаа нөлөө үзүүлж чадахаар байвал түүнийг материаллаг гэж үзнэ. Материаллаг байдал нь тухайн нөхцөл байдлын хүрээнд шүүн тунгаах уг орхигдуулалт буюу буруу илэрхийлэлтийн шинж төрөл ба хэмжээнээс хамаардаг. Тухайн зүйлийн хэмжээ эсвэл шинж төрөл нь, эсвэл хоёулаа нэгдсэн байдлаараа тодорхойлогч хүчин зүйл байж болох юм.

**Цэвэр хөрөнгө/өмч** гэдэг нь бүх өр төлбөрийг хассаны дараа уг байгууллагын хөрөнгөнд үлдэх хувь оролцоо юм.

**Тодруулга** нь санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулсан мэдээллээс гаднах бусад мэдээллийг агуулдаг. Тодруулга нь эдгээр тайланд толилуулсан зүйлсийн хүүрнэсэн тайлбар буюу дэлгэрэнгүй задаргаа, мөн эдгээр тайланд хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаагүй зүйлсийн талаархи мэдээллээр хангадаг.

**Орлого** гэдэг нь эздээс оруулсан хувь оролцоотой холбоотойгоос бусад байдлаар цэвэр хөрөнгө/өмчийг нэмэгдүүлэх үр дүн бүхий тухайн тайлант үед үүссэн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн нийт орлогын гүйлгээ юм.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь-д* дахин нийтэлсэн болно.

7А. Дараах нэр томъёог УСНББОУС 28, *Санхүүгийн Хэрэглүүр: Топилуулга*-д тодорхойлсон бөгөөд УСНББОУС 28-д заасан утгаар энэхүү Стандартад хэрэглэнэ:

- (а) Өмчийн хэрэглүүр гэж ангилсан, Буцаах эрхтэй санхүүгийн хэрэглүүр (УСНББОУС 28-ын 15 ба 16-р параграфт тодорхойлсон);
- (б) Өмчийн хэрэглүүр гэж ангилагдах бөгөөд байгууллага зөвхөн татан буугдсан үед түүний цэвэр хөрөнгийг хувь тэнцүүлэн бусад талд шилжүүлэх үүргийг тухайн байгууллагад хүлээлгэдэг санхүүгийн хэрэглүүр (УСНББОУС 28-ын 17 ба 18-р параграфт тодорхойлсон).

#### **Эдийн засгийн нэгдмэл байгууллага**

8. Хяналт тавигч байгууллага ба түүний хяналтанд буй аливаа байгууллагуудаас бүрдэх байгууллагуудын группыг санхүүгийн тайлагналын зорилгоор тодорхойлохын тулд энэ Стандартад эдийн засгийн нэгдмэл байгууллага гэсэн нэр томъёог ашигласан.

9. Эдийн засгийн нэгдмэл байгууллагыг илэрхийлэхийн тулд зарим үед захиргааны байгууллага, санхүүгийн байгууллага, нэгтгэсэн байгууллага, групп гэх мэт нэр томъёог ашигладаг.
10. Эдийн засгийн нэгдмэл байгууллага нь нийгмийн бодлогын болон арилжааны аль аль зорилго бүхий байгууллагуудыг агуулсан байж болно. Жишээлбэл; төрийн орон сууцны удирдах газар нь нэрлэсэн хөлстэйгээр орон байраар хангадаг байгууллагууд, түүнчлэн арилжааны зорилгоор орон сууцаар хангадаг байгууллагуудын аль алиныг агуулсан, эдийн засгийн нэгдмэл байгууллага байж болно.

#### **Ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи**

11. Хөрөнгө нь өөрийнхөө зорилтонд хүрэх арга хэрэгслээр байгууллагыг хангадаг. Байгууллагын зорилтын дагуу бараа, үйлчилгээг нийлүүлэхэд ашигладаг боловч цэвэр мөнгөн орлогын гүйлгээг шууд үүсгэн бий болгодоггүй хөрөнгүүдийг “үйлчилгээний чадавхи агуулсан” гэж ихэвчлэн нэрлэдэг. Цэвэр мөнгөн орлогын гүйлгээг бий болгоход ашигладаг хөрөнгүүдийг “ирээдүйн эдийн засгийн үр өгөөж агуулсан” гэж ихэвчлэн нэрлэдэг. Хөрөнгийг ашиглаж болох бүх зорилгыг нэгтгэн илэрхийлэхийн тулд энэ Стандарт нь хөрөнгүүдийн чухал шинж чанаруудыг тодорхойлох үүднээс “ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи” гэсэн нэр томъёог ашигласан.

#### **Улсын Үйлдвэрийн Газар**

12. [Хассан]

#### **Материаллаг байдал**

13. Орхигдуулалт эсвэл буруу илэрхийлэлт нь хэрэглэгчдийн шийдвэрт нөлөөлж чадах, иймээс материаллаг байх эсэхийг үнэлэхдээ тухайн хэрэглэгчдийн шинж төрлийг харгалзан үзэх шаардлагатай. Хэрэглэгчид нь улсын сектор, эдийн засгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн талаар зохих мэдлэгтэй бөгөөд тэд мэдээллийг ул үндэслэлтэй хянамгай байдлаар судлан мэдэх хүсэл эрмэлзэлтэй байдаг гэж төсөөлдөг. Тиймээс, ийм төлөв шинж бүхий хэрэглэгчдийн шийдвэрийн үнэлгээ болон гаргалтанд хэрхэн нөлөө үзүүлэхээр ул үндэслэлтэйгээр хүлээгдэж болохыг уг үнэлэлтэнд харгалзан үзэх шаардлагатай.

#### **Цэвэр хөрөнгө/Өмч**

14. Цэвэр хөрөнгө/өмч нь санхүүгийн байдлын тайлан дахь үлдэх хэмжүүрийг (хөрөнгөөс өр төлбөрийг хасах) илэрхийлэхийн тулд энэ Стандартад ашигласан нэр томъёо юм. Цэвэр хөрөнгө/өмч нь эерэг эсвэл сөрөг утгатай байж болно. Хэрэв утга нь ойлгомжтой бол цэвэр хөрөнгө/өмчийн оронд өөр нэр томъёог ашиглаж болно.

## Санхүүгийн тайлангийн зорилго

15. Санхүүгийн тайлан нь байгууллагын санхүүгийн байдал ба санхүүгийн үр дүнгийн бүтэцчилсэн илэрхийлэл юм. Нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн зорилго нь нөөцийн хуваарилалтын талаархи шийдвэрийн үнэлгээ ба шийдвэр гаргалтын хувьд янз бүрийн хэрэглэгчдэд ач холбогдолтой уг байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тухай мэдээллээр хангах явдал юм. Ялангуяа, улсын секторын хувьд нийтлэг зорилготой санхүүгийн тайлагналын зорилго нь шийдвэр гаргалтанд ач холбогдолтой мэдээллээр хангах ба түүнд хариуцуулан өгсөн нөөцийн талаархи тухайн байгууллагын хариуцлагын үр дүнг дараах байдлаар харуулахад оршино:
- (а) Санхүүгийн нөөцийн эх үүсвэр, хуваарилалт, ашиглалтын талаархи мэдээллээр хангах;
  - (б) Байгууллага нь үйл ажиллагаагаа хэрхэн санхүүжүүлсэн бөгөөд мөнгөний хэрэгцээ шаардлагаа хэрхэн хангасан талаархи мэдээллээр хангах;
  - (в) Үйл ажиллагаагаа санхүүжүүлэх, өр төлбөр болон санхүүгийн амлалтаа биелүүлэх тухайн байгууллагын чадвар, боломжийг үнэлэхэд чухал ач холбогдолтой мэдээллээр хангах;
  - (г) Байгууллагын санхүүгийн төлөв байдал болон түүний өөрчлөлтийн талаархи мэдээллээр хангах; ба
  - (д) Байгууллагын үр дүнг түүний үйлчилгээний өртөг зардал, үр ашиг, биелэлтээр үнэлэхэд ач холбогдолтой, нэгтгэсэн мэдээллээр хангах.
16. Тасралтгүй үйл ажиллагаанд шаардлагатай нөөцийн түвшин, тасралтгүй үйл ажиллагаагаар бий болгож болох нөөц, холбогдох эрсдэл ба тодорхойгүй байдлыг урьдчилан таамаглахад ач холбогдолтой мэдээллээр хангаснаар, нийтлэг зорилготой санхүүгийн тайлан нь мөн урьдчилан таамаглалын буюу хэтийн чиг үүрэгтэй байдаг. Санхүүгийн тайлагнал нь хэрэглэгчдийг дараах мэдээллээр бас хангаж болох юм:
- (а) Хуулиар батлагдсан төсвийн дагуу нөөцийг олж авсан ба ашиглан зарцуулсан эсэхийг харуулах; ба
  - (б) Зохих хууль тогтоох байгууллагаас тогтоосон хуулийн болон гэрээний шаардлагууд, үүн дотроо санхүүгийн хэмжээ хязгаарын дагуу олж авсан ба ашиглан зарцуулсан эсэхийг харуулах.
17. Эдгээр зорилтыг хангахын тулд санхүүгийн тайлан нь байгууллагын дараах зүйлсийн талаархи мэдээллээр хангадаг:
- (а) Хөрөнгө;
  - (б) Өр төлбөр;
  - (в) Цэвэр хөрөнгө/өмч;
  - (г) Орлого;

- (д) Зардал;
- (е) Цэвэр хөрөнгө/өмчийн бусад өөрчлөлтүүд; ба
- (ж) Мөнгөн гүйлгээ.

18. Санхүүгийн тайланд тусгагдсан мэдээлэл нь 15-р параграфт дурдсан, зорилтуудыг биелүүлэх зорилгод хамааралтай боловч тэдгээр бүх зорилтыг биелүүлэх боломж олгох магадал багатай байдаг. Менежерүүд нь үйлчилгээний нийлүүлэлт, түүнчлэн санхүүгийн зорилтуудад хүрэх хариуцлага хүлээдэг тул үндсэн зорилго нь ашгийн төлөө бус байгууллагуудын хувьд ялангуяа ийм тохиолдол үүсэх магадлалтай байдаг. Байгууллагын тухайн тайлант үеийн үйл ажиллагааны талаар илүү дэлгэрэнгүй дүр зургийг гаргахын тулд санхүүгийн тайлангаас гадна нэмэлт мэдээллийг, үүн дотроо санхүүгийн бус тайлангуудыг бэлтгэж болох юм.

### **Санхүүгийн тайлангийн хувьд хүлээх хариуцлага**

19. Санхүүгийн тайланг бэлтгэх, толилуулах хариуцлага нь нэг улс орны хэмжээнд, түүнчлэн улс орон бүрд өөр өөр байдаг. Мөн түүнчлэн, улс орон нь санхүүгийн тайланг бэлтгэх хариуцлага бүхий этгээд ба тухайн санхүүгийн тайланг зөвшөөрөн батлах буюу толилуулах этгээдийг ялган заагласан байж болно. Бие даасан байгууллагуудын (Засгийн газрын агентлаг буюу түүнтэй адилтгах байгууллага гэх мэт) санхүүгийн тайланг бэлтгэх хариуцлага хүлээж болох хүмүүс буюу албан тушаалын жишээнд тухайн байгууллагыг удирдаж буй хүн (орон тооны дарга буюу гүйцэтгэх захирал) болон төв санхүүгийн агентлагийн дарга (буюу хянагч, ерөнхий нягтлан бодогч гэх мэт санхүүгийн удирдах албан тушаалтан) хамаарна.
20. Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланг бүхэлд нь бэлтгэх хариуцлагыг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дарга (буюу хянагч, ерөнхий нягтлан бодогч гэх мэт санхүүгийн удирдах албан тушаалтан) болон Сангийн сайд (буюу түүнтэй адилтгах албан тушаалтан) ихэвчлэн хамтран хүлээдэг.

### **Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгүүд**

21. **Иж бүрэн санхүүгийн тайлан нь дараах зүйлсээс бүрдэнэ:**
- (а) **Санхүүгийн байдлын тайлан;**
  - (б) **Санхүүгийн үр дүнгийн тайлан;**
  - (в) **Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан;**
  - (г) **Мөнгөн гүйлгээний тайлан; ба**
  - (д) **Байгууллага нь өөрийн батлагдсан төсвийг олон нийтэд танилцуулдаг тохиолдолд тусдаа нэмэлт санхүүгийн тайлан эсвэл санхүүгийн тайлан дахь төсвийн багана байдлаар харуулсан, төсөв ба гүйцэтгэлийн дүнгийн зэрэгцүүлэлт;**

- (е) **Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба бусад тайлбар мэдээллээс бүрдэх тодруулга; ба**
- (ж) **УСНББОУС 1-ийн 53 ба 53А параграфуудад тусгайлан заасанчлан, өмнөх тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээлэл.**

22. 21-р параграфт жагсаан харуулсан, бүрэлдэхүүн хэсгүүдийг нэг улс орны хэмжээнд, түүнчлэн улс орон бүрд янз бүрээр нэрлэдэг. Санхүүгийн байдлын тайланг мөн баланс эсвэл хөрөнгө, өр төлбөрийн тайлан гэж нэрлэж болох юм. Санхүүгийн үр дүнгийн тайланг мөн орлого, зардлын тайлан, орлогын тайлан, үйл ажиллагааны тайлан эсвэл ашиг, алдагдлын тайлан гэж нэрлэж болно. Зарим улс оронд хүснэгт хэлбэрээр илэрхийлсэн зүйлсийг тодруулгад тусган оруулдаг байж болох юм.
23. Санхүүгийн тайлан нь тухайн тайлангийн өдрөөрх уг байгууллагын нөөц ба үүрэг, түүнчлэн тайлангийн өдрүүдийн хооронд гарсан нөөцийн хөдөлгөөний талаархи мэдээллээр хэрэглэгчдийг хангадаг. Энэхүү мэдээлэл нь бараа, үйлчилгээг тухайн түвшнээр үргэлжлүүлэн нийлүүлэх уг байгууллагын чадвар, боломж, түүнчлэн үйлчилгээ үзүүлэх өөрийн үүргийг цаашид биелүүлэхийн тулд тэрхүү тухайн байгууллагад ирээдүйд шаардлагатай байж болох нөөцийн түвшний үнэлгээ хийхэд хэрэглэгчдэд ач холбогдолтой байдаг.
24. Улсын секторын байгууллагууд нь төсвийн хязгаарт ихэвчлэн захирагдаж байдаг. Энэхүү төсвийн хязгаар нь зөвшөөрөн батлах хуулийн дагуу хүчин төгөлдөр болох төсвийн хуваарилалт эсвэл төсвийн төсөл (буюу түүнтэй адилтгах) хэлбэртэй байдаг. Улсын секторын байгууллагуудын нийтлэг зорилготой санхүүгийн тайлагнал нь хуулиар баталсан төсвийн дагуу нөөцийг олж авсан ба ашиглан зарцуулсан эсэх талаархи мэдээллээр хангаж болох юм. Батлагдсан төсвөө олон нийтэд нээлттэй байлгадаг байгууллагууд нь УСНББОУС 24, *Санхүүгийн Тайлан дахь Төсвийн Мэдээллийн Толилуулга*-ын шаардлагуудыг даган мөрдөх шаардлагатай байдаг. Санхүүгийн тайлан ба төсвийг нягтлан бодох бүртгэлийн нэг ижил сууриар бэлтгэдэг тохиолдолд энэ Стандарт нь тухайн тайлант үеийн төсөвлөсөн дүнтэй хийсэн зэрэгцүүлэлтийг санхүүгийн тайланд тусгахыг бусад байгууллагуудад зөвшөөрдөг. Эдгээр байгууллагуудын хувьд, төсөвтэй зэрэгцүүлсэн тайлагналыг янз бүрийн аргаар толилуулж болно. Үүнд:
- Төсөвлөсөн дүн ба гүйцэтгэлийн дүнгийн хувьд тусдаа баганууд бүхий санхүүгийн тайлангийн баганан хэлбэрийг ашиглах. Иж бүрэн болгох үүднээс, мөн төсөв буюу төсвийн хуваарилалтаас гажсан аливаа хэлбэлзлийг харуулах баганыг толилуулж болно; ба
  - Төсөвлөсөн дүнг хэтрүүлээгүй гэдгийг тодруулах. Хэрэв аливаа төсөвлөсөн дүн буюу төсвийн хуваарилалтыг хэтрүүлсэн, эсвэл төсвийн хуваарилалт буюу бусад хэлбэрийн зөвшөөрөлгүйгээр зардал гаргасан бол санхүүгийн тайлангийн тухайн холбогдох зүйлд хөлийн тэмдэглэл оруулах замаар дэлгэрэнгүй мэдээллийг тодруулж болно.

25. Байгууллагын үр дүн болон түүний хөрөнгийн хариуцлагыг хянан үнэлэх, түүнчлэн нөөцийн хуваарилалтын талаар шийдвэр гаргах ба шийдвэрийг үнэлэхэд хэрэглэгчдэд туслах нэмэлт мэдээллийг тухайн байгууллага толилуулахыг дэмждэг. Энэхүү нэмэлт мэдээлэл нь тухайн байгууллагын гарц ба үр дагаврын талаархи дэлгэрэнгүй мэдээллийг агуулж болох бөгөөд дараах хэлбэртэй байна: (а) үр дүнгийн үзүүлэлт, (б) үйлчилгээний үр дүнгийн тайлан, (в) хөтөлбөрийн нягтлах шалгалт, (г) тайлант үеийн туршид тухайн байгууллагын хүрсэн амжилт биелэлтийн талаархи удирдлагын бэлтгэсэн бусад тайлан.
26. Хууль тогтоомжийн, зохицуулалтын буюу гаднаас хүлээлгэсэн бусад зохицуулалтын мөрдөлт нийцэлтийн талаархи мэдээллийг байгууллага тодруулахыг бас дэмждэг. Ийм нийцэлтийн талаархи мэдээллийг санхүүгийн тайланд тусгаагүй тохиолдолд уг мэдээллийг агуулсан аливаа баримт бичигт лавлагаа үүсгэж, тодруулга хийх нь ач холбогдолтой байж болно. Үл нийцэлтийн талаархи мэдлэг нь хариуцлагын зорилгод хамааралтай байх магадлалтай бөгөөд тухайн байгууллагын үр дүн, ирээдүйн үйл ажиллагааны чиглэлийн талаархи хэрэглэгчийн үнэлгээнд нөлөө үзүүлж болох юм. Энэ нь тухайн байгууллагад ирээдүйд хуваарилагдах нөөцийн талаархи шийдвэрт мөн нөлөө үзүүлж болох юм.

## Ерөнхий шинжүүд

### Үнэн зөв толилуулга ба УСНББОУС-тай нийцсэн байдал

27. **Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үр нөлөөг УСНББОУС-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурын дагуу үнэнч шударга илэрхийлэхийг шаарддаг. Шаардлагатай тохиолдолд бусад нэмэлт тодруулгын хамтаар УСНББОУС-ыг даган мөрдөх нь үнэн зөв толилуулгад хүргэх байдлаар санхүүгийн тайланд тусгах урьдчилсан нөхцөл болдог.**
28. **Санхүүгийн тайлан нь УСНББОУС-тай нийцдэг бол байгууллага нь ийм нийцлийн талаархи дэлгэрэнгүй, тодорхой мэдэгдлийг уг санхүүгийн тайлангийн тодруулгад илэрхийлнэ. Санхүүгийн тайлан нь УСНББОУС-ын бүх шаардлагуудтай нийцсэн биш л бол байгууллага нь уг санхүүгийн тайланг УСНББОУС-тай нийцсэн гэж илэрхийлж болохгүй.**
29. Бараг бүх нөхцөл байдалд байгууллага нь тохирох УСНББОУС-ыг даган мөрдсөнөөр үнэн зөв толилуулгад хүрдэг. Үнэн зөв толилуулахын тулд байгууллагаас мөн дараах зүйлсийг шаардана:
- (а) *УСНББОУС 3 Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа-ны дагуу нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх. Тухайн нэг зүйлд*

тусгайлан мөрдөх УСНББОУС байхгүй тохиолдолд удирдлагын харгалзан үзэх эрх бүхий заавар удирдамжийн эрэмбэ дарааг УСНББОУС 3-д тодорхойлсон байдаг.

- (б) Хамааралтай, үнэн зөв илэрхийлэх, ойлгомжтой, цаг хугацаандаа, зэрэгцүүлэгдэх, шалгаж болох мэдээллээр хангах байдлаар мэдээллийг, үүн дотроо нягтлан бодох бүртгэлийн бодлогыг толилуулах.
  - (в) УСНББОУС-ын тухайн тодорхой шаардлагуудыг даган мөрдөх нь байгууллагын санхүүгийн байдал ба санхүүгийн үр дүнд тодорхой нэг ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын үзүүлэх үр нөлөөг ойлгох боломжийг хэрэглэгчдэд олгоход хангалтгүй байх тохиолдолд бусад нэмэлт тодруулгыг хийх.
30. **Ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулга эсвэл тэмдэглэл буюу тайлбар материал оруулах замаар тухайн тохиромжгүй нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сайжруулж чадахгүй юм.**
31. **Стандартын шаардлагыг даган мөрдөх нь энэхүү Стандартад заасан санхүүгийн тайлангийн зорилготой зөрчилдөхүйц тийм ташааралд хүргэнэ гэж удирдлагын зүгээс дүгнэсэн туйлын ховор тохиолдолд хэрэв холбогдох зохицуулалтын үзэл баримтлал нь УСНББОУС-аас гажихыг зөвшөөрсөн, эсвэл ямар нэг байдлаар хориглоогүй бол тухайн байгууллага нь 32-р параграфт заасан арга маягаар Стандартын уг шаардлагаас гажих буюу түүнийг даган мөрдөхгүй.**
32. **Дээрх 31-р параграфт заасны дагуу байгууллага нь Стандартын шаардлагаас гажсан тохиолдолд дараах зүйлсийн талаар тодруулга хийнэ:**
- (а) Санхүүгийн тайлан нь тухайн байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулсан гэж удирдлага дүгнэсэн эсэх;
  - (б) Үнэн зөв толилуулахын тулд тодорхой нэг шаардлагаас гажсанаас бусад тохиолдолд холбогдох УСНББОУС-ыг даган мөрдсөн эсэх;
  - (в) Байгууллагын гажсан буюу дагаж мөрдөөгүй Стандартын нэр, гажилтын шинж төрөл, үүн дотроо тухайн Стандартаар шаарддаг арга хандлага, тэрхүү арга хандлага нь энэ Стандартад заасан санхүүгийн тайлангийн зорилготой зөрчилдөхүйц тийм ташааралд нөхцөл байдлыг хүргэх болсон шалтгаан, мөн уг байгууллагын хэрэглэсэн арга хандлага;
  - (г) Тухайн шаардлагыг даган мөрдсөнөөр тайлагнах байсан санхүүгийн тайлангийн үзүүлэлт нэг бүрд уг гажилтын тайлант үе бүрд үзүүлэх санхүүгийн үр нөлөө.

33. **Байгууллага нь Стандартын зарим шаардлагаас өмнөх тайлант үед гажсан бөгөөд уг гажилт нь одоогийн тайлант үеийн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүнд нөлөөлдөг тохиолдолд тухайн байгууллага нь 32(в) ба (г) параграфт заасан тодруулгыг хийнэ.**
34. Тухайлбал; байгууллага нь хөрөнгө буюу өр төлбөрийн хэмжилтийн хувьд Стандартад заасан шаардлагаас өмнөх тайлант үед гажсан бөгөөд уг гажилт нь одоогийн тайлант үеийн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн хэмжилтэнд нөлөөлдөг тохиолдолд 33-р параграфыг дагаж мөрдөнө.
35. **Стандартын шаардлагыг даган мөрдөх нь энэхүү Стандартад заасан санхүүгийн тайлангийн зорилготой зөрчилдөхүйц тийм ташааралд хүргэнэ гэж удирдлагын зүгээс дүгнэсэн боловч холбогдох зохицуулалтын үзэл баримтлал нь Стандартын уг шаардлагаас гажихыг хориглодог туйлын ховор тохиолдолд тухайн байгууллага нь стандартын шаардлагыг даган мөрдсөнөөр үүснэ гэж өөрийн ойлгож төсөөлсөн ташаарлыг дараах зүйлсийн тодруулгыг хийх замаар боломжит хамгийн их хэмжээгээр бууруулах хэрэгтэй:**
- (a) **уг эргэлзээтэй Стандартын нэр, түүний шаардлагын шинж төрөл, тэрхүү шаардлагыг даган мөрдөх нь энэхүү Стандартад заасан санхүүгийн тайлангийн зорилготой зөрчилдөхөд хүргэхүйц тийм ташааралд тухайн нөхцөл байдлыг хүргэнэ гэж удирдлагын зүгээс дүгнэсэн учир шалтгаан; ба**
  - (б) **толилуулж буй тайлант үе бүрийн хувьд үнэн зөв толилуулгад хүргэхэд шаардлагатай гэж удирдлагын зүгээс дүгнэсэн санхүүгийн тайлангийн зүйл бүрд хийх тохируулга.**
36. Ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлыг илэрхийлдэг эсвэл илэрхийлнэ гэж үл үндэслэлтэйгээр хүлээж болох, иймээс санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай тэрхүү тайлангийн үзүүлэлт нь тэдгээр ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлыг үнэн зөв илэрхийлээгүй тохиолдолд 31-35-р параграфын зорилгын хувьд уг үзүүлэлтийг санхүүгийн тайлангийн зорилготой зөрчилдсөн гэж үзнэ. Стандартын тодорхой шаардлагыг даган мөрдөх нь энэхүү Стандартад заасан санхүүгийн тайлангийн зорилготой зөрчилдөхүйц тийм ташаарал мөн эсэхийг үнэлэхдээ удирдлага нь дараах зүйлсийг харгалзан үзнэ:
- (a) санхүүгийн тайлангийн зорилго нь тухайн нөхцөл байдалд яагаад хангагдахгүй байгаа; ба
  - (б) тухайн байгууллагын нөхцөл байдал нь стандартын уг шаардлагыг даган мөрдөж байгаа бусад байгууллагуудын нөхцөл байдлаас ямар ялгаатай эсэх. Хэрэв ижил нөхцөл байдалд байгаа бусад байгууллагууд нь уг шаардлагыг даган мөрддөг бол тухайн байгууллага уг шаардлагыг даган мөрдөх нь энэхүү Стандартад заасан санхүүгийн тайлангийн зорилготой зөрчилдөхүйц тийм



ташааралд хүргэхгүй гэсэн “няцааж болох урьдчилсан нөхцөл”-тэй байна.

37. Тухайн улс орон дахь санхүүгийн тайлагналын хууль ёсны/хуулийн шаардлагуудыг даган мөрдөхийн тулд УСНББОУС-ын шаардлагуудаас гажих нь 31-р параграфт дурдсантай адилаар, энэ Стандартад заасан санхүүгийн тайлангийн зорилготой зөрчилдөх гажилт болохгүй юм. Хэрэв ийм гажилт нь материаллаг бол байгууллага нь УСНББОУС-ыг даган мөрдөх шаардлага тавьж болохгүй.

#### **Тасралтгүй байх суурь**

38. **Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь үйл ажиллагаагаа тасралтгүй байдлаар үргэлжлүүлэн явуулах уг байгууллагын чадвар боломжийг үнэлэх хэрэгтэй. Удирдлага нь байгууллагыг татан буулгах буюу түүний үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөж байгаа эсвэл ингэхээс өөр бодит сонголтгүй байхаас бусад тохиолдолд тухайн байгууллага нь санхүүгийн тайлангаа тасралтгүй байх сууриар бэлтгэнэ. Ийм үнэлгээг хийх үедээ удирдлага нь тасралтгүй байдлаар үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах уг байгууллагын чадварт мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал буюу нөхцөл байдалтай холбоотой материаллаг эргэлзээтэй байдлыг мэдсэн тохиолдолд байгууллага нь тэдгээр эргэлзээтэй байдлын талаар тодруулга хийх хэрэгтэй. Байгууллага нь санхүүгийн тайлангаа тасралтгүй байх сууриар бэлтгээгүй бол энэ тухай, түүнчлэн уг санхүүгийн тайланг бэлтгэсэн суурь, тухайн байгууллагыг тасралтгүй байдлаар үйл ажиллагаагаа явуулж чадахгүй гэж үзсэн шалтгааны хамт тодруулна.**
39. Тухайн байгууллага нь тасралтгүй үйл ажиллагаа явуулдаг, урьдчилан харж болох ирээдүйд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах ба өөрийн хууль ёсны үүргийг биелүүлнэ гэсэн төсөөлөлд үндэслэн санхүүгийн тайланг ерөнхийдөө бэлтгэдэг. Тасралтгүй байх төсөөлөл зохистой эсэхийг үнэлэхдээ, тухайн санхүүгийн тайланг бэлтгэх хариуцлага хүлээсэн этгээд нь ирээдүйн талаархи бэлэн боломжтой байгаа бүх мэдээллийг харгалзан үзнэ. Ирээдүй гэдэг нь уг санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрсөн өдрөөс хойшхи наад зах нь арван хоёр сарын хугацааг хамрах боловч үүгээр хязгаарлагдахгүй.
40. Харгалзан үзэх хэмжээ нь тухайн нөхцөл байдал бүр дэх бодит байдлаас хамаарах бөгөөд бизнесийн байгууллагуудад ихэвчлэн хэрэглэдэг төлбөрийн чадварын сорилд үндэслэн тасралтгүй байх төсөөллийн талаархи үнэлгээг хийхгүй. Төлбөрийн чадвар ба хөрвөх чадварт үндэслэсэн тасралтгүй байдлын нийтлэг сорил нь тааламжгүй байгааг илэрхийлэх боловч тухайн байгууллага ямартаа ч тасралтгүй үйл ажиллагаа явуулна гэдгийг бусад хүчин зүйлс харуулах тийм нөхцөл байдалтай байж болно. Тухайлбал;
- (а) Засгийн газар тасралтгүй үйл ажиллагаа явуулах эсэхийг үнэлэх үед, хэдийгээр байгууллагууд нь нилээд удаан хугацаанд сөрөг дүн бүхий

цэвэр хөрөнгө/өмчтэй ажилласан боловч татвар буюу хураамж ногдуулах бүрэн эрхтэй байх нь тэдгээр байгууллагуудыг тасралтгүй үйл ажиллагаа явуулна гэж үзэхэд хүргэж болох юм; ба

- (б) Бие даасан байгууллагын хувьд, тухайн тайлангийн өдрөөрх түүний санхүүгийн байдлын тайланд хийсэн үнэлгээ нь тасралтгүй ажиллах төсөөлөл тохиромжгүй гэдгийг илэрхийлж болох юм. Гэвч уг байгууллагын тасралтгүй ажиллагааг хангах олон жилийн санхүүжилтийн хэлцэл буюу бусад хэлцэл хийгдсэн байж болно.
41. Тасралтгүй байх төсөөлөл тохиромжтой эсэх тодорхойлолт нь бүхэлдээ засгийн газартай биш, харин тухайн бие даасан байгууллагуудад юуны өмнө хамааралтай байдаг. Бие даасан байгууллагуудын хувьд тасралтгүй байх суурь тохиромжтой эсэхийг үнэлэхдээ, санхүүгийн тайланг бэлтгэх хариуцлага бүхий этгээд нь тасралтгүй байх төсөөлөл тохиромжтой гэж дүгнэх үндэслэлтэй болохын өмнө, дараах зүйлстэй холбоотой янз бүрийн хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай байж болно: (а) одоогийн болон хүлээгдэж буй үр дүн, (б) зохион байгуулалтын нэгжүүдийн хувьд хийгдэх боломжит ба зарласан бүтцийн өөрчлөлт, (в) орлогын тооцоолол буюу засгийн газрын тасралтгүй санхүүжилтийн магадлал, (г) орлох санхүүжилтийн боломжит эх үүсвэрүүд.

#### **Толилуулгын тууштай байдал**

42. **Доор дурдснаас бусад тохиолдолд, санхүүгийн тайлан дахь зүйлсийн толилуулга ба ангиллыг нэг тайлант үеэс дараагийн тайлант үед хэвээр хадгална:**
- (а) **Байгууллагын үйл ажиллагааны шинж төрлийн мэдэгдэхүйц өөрчлөлт эсвэл түүний санхүүгийн тайлангийн нягтлах шалгалтын дараа, өөр толилуулга буюу ангилал нь УСНББОУС 3-д заасан, нягтлан бодох бүртгэлийн бодлогын сонголт ба мөрдөлтийн шалгуурын хувьд илүү тохиромжтой гэдэг нь илэрхий болсон; эсвэл**
- (б) **УСНББОУС нь толилуулгын өөрчлөлт хийхийг шаардсан.**
43. Томоохон худалдан авалт буюу данснаас хасалт, эсвэл санхүүгийн тайлангийн толилуулгын нягтлах шалгалт нь тухайн санхүүгийн тайланг өөрөөр толилуулах шаардлагатай гэдгийг илэрхийлж болох юм. Жишээлбэл; байгууллага нь өөрийн хяналтанд буй хамгийн том байгууллагуудын нэг болох хадгаламжийн банкыг данснаас хассан ба үлдсэн бусад эдийн засгийн нэгдмэл байгууллага нь захиргааны болон бодлогын зөвлөх үйлчилгээг үндсэндээ эрхэлдэг байж болох юм. Энэ тохиолдолд санхүүгийн байгууллага гэсэн уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын үндсэн үйл ажиллагаанд үндэслэсэн санхүүгийн тайлангийн толилуулга нь тэрхүү шинэ эдийн засгийн нэгдмэл байгууллагатай хамааралтай байх магадлал багатай юм.
44. Өөрчилсөн толилуулга нь үнэн зөв илэрхийлэх ба тухайн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд илүү хамааралтай мэдээллээр хангах бөгөөд уг

өөрчлөгдсөн бүтцийг цаашид үргэлжлүүлэх, ингэснээр зэрэгцүүлэгдэх боломжтой байдлыг алдагдуулахгүй байх магадлалтай зөвхөн тийм тохиолдолд байгууллага нь өөрийн санхүүгийн тайлангийн толилуулгыг өөрчилнө. Толилуулгад ийм өөрчлөлт хийсэн тохиолдолд байгууллага нь өөрийн зэрэгцүүлэгдэх мэдээллийг 55 ба 56-р параграфын дагуу дахин ангилна.

#### **Материаллаг байдал ба нэгтгэн нийлүүлэлт**

45. **Ижил төсөөтэй зүйлсийн материаллаг анги тус бүрийг санхүүгийн тайланд тусад нь толилуулна. Материаллаг биш байхаас бусад тохиолдолд, ижил бус шинж төрөл буюу чиг үүрэг бүхий зүйлсийг тусад нь толилуулна.**
46. Маш олон тооны ажил гүйлгээ буюу бусад үйл явдлуудыг тэдгээрийн шинж төрөл эсвэл чиг үүргийн дагуу ангиудад нэгтгэн нийлүүлэх боловсруулалтын үр дүнд санхүүгийн тайланг бэлтгэдэг. Нэгтгэн нийлүүлэх ба ангилах боловсруулалтын эцсийн үе шат нь хураангуйлж, ангилсан мэдээний толилуулга бөгөөд энэ нь санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд эсвэл тодруулгад тусгах мөрийн зүйлсийг бүрдүүлдэг. Хэрэв мөрийн зүйл нь дангаараа материаллаг биш бол тэдгээрийг санхүүгийн тайланд эсвэл тодруулгад тусгахдаа бусад мөрийн зүйлстэй нэгтгэн нийлүүлдэг. Санхүүгийн тайланд тусдаа толилуулах үндэслэл болохуйц хангалттай материаллаг биш зүйл нь тодруулгад тусдаа толилуулахад хангалттай материаллаг байж болох юм.
47. Материаллаг байдлын ойлголт ухагдахууныг даган мөрдөх нь хэрэв тухайн мэдээлэл материаллаг бус бол УСНББОУС-д заасан тодруулгын тусгай шаардлагыг мөрдөх шаардлагагүй гэсэн үг биш юм.

#### **Цэвэр дүн гаргах**

48. **УСНББОУС-аар шаардсан буюу зөвшөөрснөөс бусад тохиолдолд хөрөнгө ба өр төлбөр, эсвэл орлого ба зардлыг хооронд нь хааж, цэвэр дүнг гаргахгүй.**
49. Хөрөнгө ба өр төлбөр, орлого ба зардлыг тус тусад нь тайлагнах нь чухал ач холбогдолтой байдаг. Цэвэр дүн гаргалт нь ажил гүйлгээ буюу бусад үйл явдлын мөн чанарыг тусган илэрхийлэхээс бусад тохиолдолд санхүүгийн үр дүнгийн тайланд эсвэл санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнг гаргах нь (а) тухайн гарч тохиолдсон ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлыг ойлгох, (б) уг байгууллагын ирээдүйн мөнгөн гүйлгээг үнэлэх хэрэглэгчдийн чадвар, боломжийг бууруулдаг. Хөрөнгийг түүний үнэлгээний хасагдуулгыг хассан цэвэр дүнгээр хэмжих нь цэвэр дүн гаргалт биш юм. Жишээлбэл; бараа материалаас хоцрогдлын хасагдуулгыг хасах, авлагаас түүний найдваргүй авлагын нөөцийг хасах.
50. УСНББОУС 9, *Арилжааны Ажил Гүйлгээний Орлого* нь орлогыг тодорхойлсон бөгөөд түүнийг хүлээн авсан буюу авах зүйлсийн бодит үнэ

цэнээр хэмжих ба тухайн байгууллагын зөвшөөрөн олгосон аливаа худалдааны хөнгөлөлт болон тоо хэмжээний хөнгөлөлтийн дүнг харгалзан хасахыг шаарддаг. Орлого бий болгодоггүй боловч орлого бий болгох үндсэн үйл ажиллагааны хувьд дагалдах шинж чанартай бусад ажил гүйлгээг байгууллага нь өөрийн ердийн үйл ажиллагааны явцад гүйцэтгэдэг. Ийм ажил гүйлгээний толилуулга нь тухайн ажил гүйлгээ буюу бусад үйл явдлын мөн чанарыг тусгах тохиолдолд байгууллага нь уг ажил гүйлгээнээс үүссэн холбогдох зардлыг хассан аливаа цэвэр орлогын дүнгээр тэрхүү ажил гүйлгээний үр дүнг толилуулдаг. Жишээлбэл;

- (а) эргэлтийн бус хөрөнгө, үүн дотроо хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны хөрөнгийн дансны хасалтын олз буюу гарзыг тэрхүү данснаас хасалтаас хүлээн авах орлогоос тухайн хөрөнгийн дансны үнэ ба холбогдох борлуулалтын зардлыг хассанаар толилуулдаг; ба
- (б) УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-ийн дагуу хүлээн зөвшөөрсөн бөгөөд гуравдагч талтай байгуулсан гэрээний (жишээ нь; бэлтгэн нийлүүлэгчийн баталгааны гэрээ) дагуу нөхөн төлөгдөх нөөц сантай холбоотой зардлыг холбогдох нөхөн төлбөрийг хассан цэвэр дүнгээр тусгаж болно.

- 51. Түүнчлэн, ижил төсөөтэй ажил гүйлгээний бүлгээс үүссэн олз ба гарзыг цэвэр дүнгээр нь тайлагнадаг. Жишээлбэл; гадаад валютын ханшийн олз ба гарз, эсвэл борлуулах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүрээс үүссэн олз ба гарз. Гэхдээ ийм олз, гарз нь материаллаг байвал тэдгээрийг тус тусад нь тайлагнана.
- 52. Мөнгөн гүйлгээний цэвэр дүнг гаргалтыг УСНББОУС 2, *Мөнгөн Гүйлгээний Тайлан*-д авч үзсэн.

### **Зэрэгцүүлэгдэх мэдээлэл**

#### *Зэрэгцүүлэгдэх хамгийн наад захын мэдээлэл*

- 53. **УСНББОУС нь өөрөөр шаардсан буюу зөвшөөрснөөс бусад тохиолдолд байгууллага нь тухайн санхүүгийн тайланд тайлагнасан бүх дүнгийн хувьд харгалзах өмнөх тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулах хэрэгтэй. Хэрэв тухайн тайлант үеийн санхүүгийн тайланг ойлгоход хамааралтай бол байгууллага нь хүүрнэсэн ба тайлбарласан мэдээллийн хувьд мөн зэрэгцүүлэгдэх мэдээллийг тусган оруулна.**
- 53А. **Байгууллага хамгийн наад зах нь, өмнөх тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээллийн хамтаар санхүүгийн байдлын нэг тайлан, өмнөх тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээллийн хамтаар санхүүгийн үр дүнгийн нэг тайлан, өмнөх тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээллийн хамтаар мөнгөн гүйлгээний нэг тайлан, өмнөх тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээллийн хамтаар цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэг тайлан болон холбогдох тодруулгыг толилуулна.**

54. Зарим тохиолдолд өмнөх тайлант үеийн (үеүдийн) санхүүгийн тайланд тусгасан, хүүрнэсэн мэдээлэл нь тухайн тайлант үед мөн хамааралтай хэвээр байдаг. Жишээлбэл; өмнөх тайлант үеийн эцсээр үр дагавар нь тодорхойгүй буюу хараахан шийдэгдээгүй байсан хуулийн зарга маргааны талаархи дэлгэрэнгүй мэдээллийг байгууллага нь тухайн тайлант үед тусган тодруулдаг. Өмнөх тайлант үеийн эцэст байсан тодорхойгүй зүйлсийн талаархи мэдээллийн тодруулга ба уг тодорхойгүй байдлыг шийдвэрлэхийн тулд тухайн тайлант үеийн туршид авсан арга хэмжээний талаархи мэдээллийн тодруулга нь хэрэглэгчдэд ач холбогдолтой байж болно.
55. **Санхүүгийн тайлан дахь зүйлсийн толилуулга буюу ангилалд нэмэлт өөрчлөлт оруулсан бол дахин ангилал хийх практик боломжгүй байхаас бусад тохиолдолд зэрэгцүүлэгдэх дүнгүүдийг мөн дахин ангилна. Зэрэгцүүлэгдэх дүнгүүдийг дахин ангилсан тохиолдолд байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:**
- (a) дахин ангиллын шинж төрөл;
  - (б) дахин ангилсан зүйл эсвэл анги тус бүрийн дүн; ба
  - (в) дахин ангиллын шалтгаан.
56. **Зэрэгцүүлэгдэх дүнгүүдийг дахин ангилах практик боломжгүй тохиолдолд байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:**
- (a) дүнгүүдийг дахин ангилаагүй шалтгаан; ба
  - (б) хэрэв дүнгүүдийг дахин ангилсан бол хийгдэх байсан тохируулгын шинж төрөл.
57. Мэдээллийн тайлант үеүдийн хоорондох зэрэгцүүлэгдэх байдлыг сайжруулах нь ялангуяа урьдчилан таамаглах зорилгоор санхүүгийн мэдээллийн хандлагыг үнэлэх боломж бүрдүүлснээр хэрэглэгчдийн шийдвэр гаргалт болон шийдвэрийн үнэлгээнд туслалцаа үзүүлдэг. Тайлант үетэй зэрэгцүүлэлт хийхийн тулд өмнөх тодорхой тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээллийг зарим тохиолдолд дахин ангилах практик боломжгүй байдаг. Жишээлбэл; дахин ангилал хийх боломжтой байдлаар өмнөх тайлант үеүдийн мэдээг цуглуулан бүрдүүлээгүй ба уг мэдээллийг дахин бүрдүүлэх практик боломжгүй байж болох юм.
58. Байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн бодлогоо өөрчилсөн эсвэл алдааг засварласан тохиолдолд зэрэгцүүлэгдэх мэдээлэлд хийх шаардлагатай залруулгыг УСНББОУС 3-д заасан байдаг.

## **Бүтэц ба агуулга**

### **Танилцуулга**

59. Энэхүү Стандарт нь санхүүгийн байдлын тайланд, санхүүгийн үр дүнгийн тайланд, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд тодорхой толилуулга хийхийг шаарддаг бөгөөд бусад мөрийн зүйлсийн толилуулгыг эдгээр

санхүүгийн тайланд эсвэл тодруулгад хийхийг шаарддаг. Мөнгөн гүйлгээний тайлангийн толилуулгын шаардлагуудыг УСНББОУС 2-т заасан.

60. Энэхүү Стандартад 'толилуулга' гэсэн нэр томъёог зарим үед өргөн утгаар ашигласан бөгөөд энэ нь (а) санхүүгийн байдлын тайланд, (б) санхүүгийн үр дүнгийн тайланд, (в) цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд, (г) мөнгөн гүйлгээний тайланд, түүнчлэн тодруулгад тусгасан зүйлсийг агуулах юм. Бусад УСНББОУС-аар мөн толилуулга хийхийг шаарддаг. Энэ Стандартт эсвэл бусад Стандартын аль нэг хэсэгт өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд ийм толилуулгыг санхүүгийн байдлын тайланд, санхүүгийн үр дүнгийн тайланд, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд, мөнгөн гүйлгээний тайланд (аль хамааралтай тайланд) эсвэл тодруулгад хийнэ.

### **Санхүүгийн тайлангийн ялган тодорхойлолт**

61. **Санхүүгийн тайланг ойлгомжтой байдлаар ялган тодорхойлох ба хэвлэн нийтэлж буй баримт бичиг дэх бусад мэдээллээс ялган илэрхийлэх хэрэгтэй.**
62. УСНББОУС-ыг зөвхөн санхүүгийн тайланд мөрдөх бөгөөд жилийн тайлан илтгэл буюу өөр бусад баримт бичигт толилуулж буй бусад мэдээлэлд мөрдөхгүй. Иймээс хэрэглэгчид нь УСНББОУС-ыг ашиглан бэлтгэсэн мэдээллийг тэдэнд ач холбогдолтой байж болох боловч стандартын шаардлагуудад хамаарахгүй бусад мэдээллээс ялган зааглаж чадахаар байх нь чухал ач холбогдолтой юм.
63. **Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг нэг бүрийг ойлгомжтой байдлаар ялган тодорхойлох хэрэгтэй. Түүнчлэн, дараах мэдээллийг тов тодорхой харуулах ба толилуулж буй мэдээллийг зөв ойлгоход зайлшгүй шаардлагатай тохиолдолд давтан илэрхийлнэ:**
- (а) тайлагнагч байгууллагын нэр буюу ялган тодорхойлох бусад илэрхийлэлт ба өмнөх тайлант үеийн эцсээс хойш уг мэдээлэлд орсон аливаа өөрчлөлт;
  - (б) бие даасан байгууллагын эсвэл эдийн засгийн нэгдмэл байгууллагын санхүүгийн тайлан эсэх;
  - (в) санхүүгийн тайланд хамаарах тайлангийн өдөр буюу хамрагдах тайлант үе, энэ нь санхүүгийн тайлангийн тухайн бүрэлдэхүүн хэсгийн хувьд тохиромжтой эсэх;
  - (г) **УСНББОУС 4, Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө**-д тодорхойлсон толилуулгын валют; ба
  - (д) санхүүгийн тайланд дүнг толилуулахдаа хэрэглэсэн бүхэлчлэлийн түвшин.
64. Санхүүгийн тайлангийн хуудас бүрийн хувьд хуудасны нэр гарчиг болон баганын толгойн хураангуйлсан нэрийг бичсэнээр 63-р параграфт заасан

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЛИЛУУЛГА

шаардлагуудыг үндсэндээ ханган биелүүлнэ. Ийм мэдээллийг толилуулах хамгийн сайн арга замыг тодорхойлохдоо шүүн тунгаалт хийх шаардлагатай байдаг. Жишээлбэл; санхүүгийн тайланг цахим хэлбэрээр толилуулах тохиолдолд тусдаа хуудсуудыг байнга ашиглах шаардлагагүй байдаг; санхүүгийн тайланд тусгасан мэдээллийн ойлгомжтой байдлыг хангахын тулд дээр дурдсан зүйлсийг байнга толилуулна.

65. Толилуулгын валютын мянгачилсан эсвэл саячилсан дүнгээр мэдээллийг толилуулснаар санхүүгийн тайланг ойлгоход ихэвчлэн илүү хялбар болгодог. Толилуулга дахь бүхэлчлэлийн түвшинг заасан бөгөөд материаллаг мэдээллийг орхигдуулаагүй тохиолдолд ингэж бүхэлчлэхийг зөвшөөрнө.

### Тайлант үе

66. **Санхүүгийн тайланг хамгийн наад зах нь жил бүр толилуулна. Байгууллагын тайлангийн өдрийг өөрчилсөн ба жилийн санхүүгийн тайланг нэг жилээс урт эсвэл богино хугацаагаар толилуулсан тохиолдолд уг байгууллага нь тухайн санхүүгийн тайлангийн хамрах тайлант үеэс гадна дараах зүйлсийг тодруулна:**

- (а) урт эсвэл богино хугацааг ашигласан шалтгаан; ба
- (б) санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан гэх мэт зарим тайлангууд болон холбогдох тодруулгын хувьд зэрэгцүүлэгдэх дүнгүүд нь бүхэлдээ зэрэгцүүлэгдэх боломжгүй болсон тухай.

67. Онцгой нөхцөл байдалд, байгууллага нь тухайлбал, тайлагналын циклийг төсөвлөлтийн циклтэй илүү нийцүүлэхийн тулд өөрийн тайлангийн өдрийг өөрчлөхөөр шийдвэрлэж эсвэл түүнээс ингэж өөрчлөхийг шаардаж болох юм. Ийм тохиолдолд (а) хэрэглэгчид нь тухайн тайлант үеийн хувьд харуулсан дүнгүүд, түүнчлэн зэрэгцүүлэгдэх дүнгүүд нь зэрэгцүүлэгдэх боломжгүй болсон гэдгийг мэдэж байх, ба (б) тайлангийн өдрийн өөрчлөлтийн шалтгааныг тодруулах нь чухал ач холбогдолтой байдаг. Өөр нэг жишээ нь; мөнгөн суурьт нягтлан бодох бүртгэлээс аккруэл суурьт нягтлан бодох бүртгэлд шилжсэн тохиолдолд нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх боломжтой болохын тулд байгууллага нь тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх байгууллагуудын тайлангийн өдрийг өөрчилдөг.

68. Ерөнхийдөө, нэг жилийн хугацаанд хамаарах санхүүгийн тайланг тууштай бэлтгэж, толилуулдаг. Гэвч практик шалтгааны улмаас зарим байгууллага нь өөр, тухайлбал; 52 долоо хоногийн хугацаагаар тайлагнахыг илүүд үздэг. Ингэж толилуулсан санхүүгийн тайлан нь нэг жилээр толилуулсан санхүүгийн тайлангаас материаллаг зөрүүтэй байх магадлал багатай учраас энэ Стандарт нь ийм практикыг хориглодоггүй.

**Цаг хугацаандаа байх**

69. Тайлангийн өдрөөс хойшхи ул үндэслэлтэй хугацааны дотор санхүүгийн тайланг хэрэглэгчдэд хүргэн танилцуулахгүй бол түүний ач холбогдолтой байдал буурдаг. Байгууллага нь тайлангийн өдрөөс хойш 6 сарын дотор өөрийн санхүүгийн тайланг гарган танилцуулах байр суурьтай байвал зохино. Байгууллагын үйл ажиллагааны нарийн цогц байдал гэх мэт байнгын хүчин зүйлс нь санхүүгийн тайланг цаг хугацаанд нь гарган тайлагнаж чадахгүй байх хангалттай зохих шалтгаан биш юм. Ингэж гарган тайлагнах илүү тусгайлсан эцсийн хугацааг эрх зүйн олон орчинд хууль тогтоомж болон зохицуулалтаар заасан байдаг.

**Санхүүгийн байдлын тайлан**

*Эргэлтийн/эргэлтийн бус ангиллын ялгаа*

70. **Хөрвөх чадварт үндэслэсэн толилуулга нь үнэн зөв илэрхийлэх ба илүү их хамааралтай мэдээллээр хангадаг байхаас бусад тохиолдолд байгууллага нь эргэлтийн ба эргэлтийн бус хөрөнгө, богино ба урт хугацаат өр төлбөрийг 76-87-р параграфт заасны дагуу санхүүгийн байдлын тайландаа тусдаа ангиллууд байдлаар толилуулна. Үүнээс гажих бусад тохиолдлыг мөрдөж байгаа үед бүх хөрөнгө, өр төлбөрийг хөрвөх чадварын дарааллаар толилуулна.**
71. **Толилуулгын аль ч аргыг хэрэглэж байлаа гэсэн (а) тайлант үеийн эцсээс хойш 12 сараас илүүгүй хугацаанд; ба (б) тайлант үеийн эцсээс хойш 12 сараас илүү хугацаанд нөхөгдөх буюу барагдуулахаар хүлээгдэж буй дүнгүүдийг нэгтгэн нийлүүлсэн хөрөнгө, өр төлбөрийн мөрийн зүйл тус бүрийн хувьд байгууллага нь 12 сараас илүү хугацааны дараа нөхөгдөх буюу барагдуулахаар хүлээгдэж буй дүнгүүдийг тусдаа толилуулна.**
72. Байгууллага нь илт ялган тодорхойлж болох үйл ажиллагааны циклийн дотор бараа, үйлчилгээг нийлүүлдэг тохиолдолд эргэлтийн ба эргэлтийн бус хөрөнгө, богино ба урт хугацаат өр төлбөрийн санхүүгийн байдлын тайлан дахь тусдаа ангилал нь ажлын капитал байдлаар тасралтгүй эргэлтэнд орж байгаа цэвэр хөрөнгүүдийг тухайн байгууллагын урт хугацааны үйл ажиллагаанд ашиглагдах хөрөнгүүдээс ялган заагласнаар чухал ач холбогдолтой мэдээллээр хангадаг. Мөн энэ нь богино хугацаат үйл ажиллагааны циклийн дотор хэрэгжихээр хүлээгдэж буй хөрөнгүүд, түүнчлэн уг хугацааны дотор төлж барагдуулах өр төлбөрийг ялган илэрхийлдэг.
73. Санхүүгийн байгууллага гэх мэт зарим байгууллагууд нь илт ялган тодорхойлж болох үйл ажиллагааны циклийн дотор бараа, үйлчилгээг нийлүүлдэггүй учраас эргэлтийн/эргэлтийн бус гэсэн толилуулгын оронд хөрөнгө, өр төлбөрийг тэдгээрийн хөрвөх чадварын өсөх эсвэл буурах дарааллаар толилуулах нь үнэн зөв илэрхийлэх ба илүү хамааралтай байх мэдээллээр хангадаг.



74. 70-р параграфыг мөрдөх үед хэрэв үнэн зөв илэрхийлэх ба илүү хамааралтай мэдээллээр хангахаар байвал байгууллага нь өөрийн зарим хөрөнгө, өр төлбөрийг эргэлтийн/эргэлтийн бус гэсэн ангиллын дагуу, харин бусдыг нь тэдгээрийн хөрвөх чадварын дарааллаар толилуулахыг зөвшөөрдөг. Байгууллага нь янз бүрийн олон төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг тохиолдолд толилуулгын ийм холимог суурь ашиглах шаардлагатай байж болно.
75. Хөрөнгө, өр төлбөрийн хэрэгжилтийн хүлээгдэж буй хугацааны талаархи мэдээлэл нь байгууллагын хөрвөх чадвар ба төлбөрийн чадварыг үнэлэхэд ач холбогдолтой байдаг. УСНББОУС 30 *Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга* нь санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн дуусгавар болох хугацааны талаар тодруулга хийхийг шаарддаг. Санхүүгийн хөрөнгөнд худалдааны ба бусад авлага, санхүүгийн өр төлбөрт худалдааны ба бусад өглөг хамаардаг. Бараа материал, нөөц сан гэх мэт мөнгөн зүйлсийн бус хөрөнгө, өр төлбөрийн нөхөлт ба барагдуулалтын хүлээгдэж буй хугацааны талаархи мэдээлэл нь хөрөнгө, өр төлбөрийг эргэлтийн эсвэл эргэлтийн бус гэж ангилахад мөн ач холбогдолтой байдаг.

*Эргэлтийн хөрөнгө*

76. **Хөрөнгө нь дараах шалгууруудын аль нэгийг хангах тохиолдолд түүнийг эргэлтийн хөрөнгө гэж ангилна:**
- (а) **тухайн хөрөнгийг хэрэгжүүлэхээр хүлээж буй эсвэл уг байгууллагын хэвийн үйл ажиллагааны циклийн явцад борлуулах буюу ашиглан зарцуулахаар эзэмшиж байгаа;**
  - (б) **тухайн хөрөнгийг үндсэндээ худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж байгаа;**
  - (в) **тайлант үеийн эцсээс хойш 12 сарын дотор тухайн хөрөнгийг хэрэгжүүлэхээр хүлээгдэж буй; эсвэл**
  - (г) **тухайн хөрөнгө нь тайлант үеийн эцсээс хойш наад зах нь 12 сарын хугацаанд арилжаа гүйлгээ хийхээр эсвэл өр төлбөрийг барагдуулахаар ашиглахыг нь хязгаарлаагүй мөнгө буюу мөнгөтэй адилтгах хөрөнгө (УСНББОУС 2-т тодорхойлсоны дагуу) байх.**

**Бусад бүх хөрөнгийг эргэлтийн бус гэж ангилна.**

77. Биет хөрөнгө, биет бус хөрөнгө болон урт хугацаат шинж чанартай санхүүгийн хөрөнгийг багтаан илэрхийлэхийн тулд энэхүү Стандартад 'эргэлтийн бус' гэсэн нэр томъёог ашигладаг. Утга агуулга нь ойлгомжтой байвал өөр хувилбар нэршил ашиглахыг хориглохгүй.
78. Байгууллагын үйл ажиллагааны цикл гэдэг нь орц буюу нөөцийг гарц болгон хувиргахад зарцуулах хугацаа юм. Жишээлбэл; засгийн газар нь улсын секторын байгууллагуудад нөөцийг шилжүүлэх ба тэдгээр байгууллага нь тухайн засгийн газрын хүссэн нийгэм, улс төр, эдийн

засгийн үр дүнд хүрэхийн тулд уг нөөцийг бараа, үйлчилгээ болгон хувиргадаг. Байгууллагын хэвийн үйл ажиллагааны цикл нь илт тодорхой биш тохиолдолд түүний үргэлжлэх хугацааг 12 сар байна гэж үздэг.

79. Хэдийгээр тайлант үеийн эцсээс хойш 12 сарын дотор хэрэгжихээр хүлээгдээгүй байлаа ч гэсэн хэвийн үйл ажиллагааны циклийн нэг хэсэг болгон хөрөнгийг (татварын авлага, хэрэглэгчдээс авах авлага, торгуулийн болон зохицуулалтын хураамжийн авлага, бараа материал, хуримтлагдсан хөрөнгө оруулалтын авлага гэх мэт) хэрэгжүүлсэн, зарцуулсан буюу борлуулсан тохиолдолд түүнийг эргэлтийн хөрөнгөнд хамруулна. Юуны өмнө худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгө (жишээлбэл; УСНББОУС 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*-ийн дагуу худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж ангилсан, зарим санхүүгийн хөрөнгө) ба эргэлтийн бус санхүүгийн хөрөнгийн тайлант хугацаанд хамаарах хэсэг нь мөн эргэлтийн хөрөнгөнд хамаарна.

*Богино хугацаат өр төлбөр*

80. **Өр төлбөр нь дараах шалгууруудын аль нэгийг хангах тохиолдолд түүнийг богино хугацаат гэж ангилна:**

- (а) байгууллагын хэвийн үйл ажиллагааны циклийн дотор өр төлбөрийг барагдуулахаар хүлээгдэж буй;
- (б) өр төлбөрийг юуны өмнө худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж байгаа;
- (в) тайлант хугацааны эцсээс хойш 12 сарын дотор барагдуулах хугацаатай өр төлбөр; эсвэл
- (г) байгууллага нь өр төлбөрийн барагдуулалтыг тухайн тайлант хугацааны эцсээс хойш наад зах нь 12 сарын хугацаагаар хойшлуулах нөхцөлт бус эрхгүй байх (84-р параграфыг үзнэ үү). Харилцагч нөгөө талын сонголтоор хийгдэх ба өмчийн хэрэглүүр гаргаснаар өр төлбөрийг барагдуулахад хүргэж болох тухайн өр төлбөрийн нөхцөл нь түүний ангилалд нөлөөлдөггүй байх.

**Бусад бүх өр төлбөрийг урт хугацаат гэж ангилна.**

81. Засгийн газрын шилжүүлгийн өглөг, ажиллагчдын болон бусад үйл ажиллагааны зардлын хуримтлагдсан өглөг гэх мэт зарим богино хугацаат өр төлбөр нь тухайн байгууллагын хэвийн үйл ажиллагааны циклд ашиглагдах ажлын капиталын нэг хэсэг байдаг. Ийм өр төлбөрүүд нь хэдийгээр тайлант үеийн эцсээс хойш 12 сараас илүү хугацаанд барагдах хугацаатай байсан ч гэсэн тэдгээрийг богино хугацаат өр төлбөр гэж ангилна. Байгууллагын хөрөнгө, өр төлбөрийн ангилалд хэвийн үйл ажиллагааны нэг ижил циклийг баримтална. Байгууллагын хэвийн үйл ажиллагааны цикл нь илт тодорхой биш тохиолдолд түүний үргэлжлэх хугацааг 12 сар байна гэж үзнэ.

82. Бусад богино хугацаат өр төлбөр нь хэвийн үйл ажиллагааны циклийн нэг хэсэг байдлаар барагдахгүй боловч тайлант үеийн эцсээс хойш 12 сарын дотор барагдах хугацаатай эсвэл тэдгээрийг юуны өмнө худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж байдаг. Жишээлбэл; УСНББОУС 29-ийн дагуу худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж ангилсан зарим санхүүгийн өр төлбөр, банкны овердрафт, урт хугацаат санхүүгийн өр төлбөрийн тайлант хугацаанд хамаарах хэсэг, ногдол ашгийн өглөг буюу адилтгах хуваарилалтын өглөг, орлогын албан татварын өглөг, бусад худалдааны бус өглөг. Урт хугацааны санхүүжилтээр хангах (өөрөөр хэлбэл, байгууллагын хэвийн үйл ажиллагааны циклд ашиглагдах ажлын капиталын нэг хэсэг болохгүй) ба тайлант үеийн эцсээс хойш 12 сарын дотор барагдуулахгүй санхүүгийн өр төлбөр нь 85 ба 86-р параграфуудын дагуу урт хугацаат өр төлбөр болох юм.
83. Дараах нөхцөлд ч гэсэн байгууллага нь санхүүгийн өр төлбөрөө тайлант үеийн эцсээс хойш 12 сарын дотор барагдуулахаар болсон тохиолдолд түүнийг богино хугацаат өр төлбөр гэж ангилна:
- (а) анхны нөхцөл нь 12 сараас урт хугацаатай байсан; ба
  - (б) дахин санхүүжүүлэх эсвэл урт хугацаанд төлөхөөр төлбөрийн хуваарийг шинэчлэн гаргасан гэрээ хэлцэл нь тайлант үеийн эцсээс хойш боловч санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрөхөөс өмнө хийгдсэн.
84. Байгууллага нь одоо байгаа зээлийн шугамын хүрээнд өр төлбөрийг дахин санхүүжүүлэх буюу тайлант хугацааны эцсээс хойш наад зах нь 12 сарын хугацаагаар төлөлтийг хойшлуулахаар хүлээгдэж буй бөгөөд тэгэх сонголттой тохиолдолд, хэдийгээр ийм арга хэмжээ авахгүй бол өр төлбөрийг богино хугацаанд төлөх төлбөрийн хугацаатай байлаа ч гэсэн түүнийг урт хугацаат өр төлбөр гэж ангилна. Харин өр төлбөрийн дахин санхүүжүүлэлт буюу хойшлуулалт нь тухайн байгууллагын сонголтөөс хамаарахгүй (тухайлбал; дахин санхүүжүүлэх гэрээ хэлцэл байхгүй) тохиолдолд уг байгууллага нь дахин санхүүжүүлэх боломжийг харгалзан үзэхгүй бөгөөд өр төлбөрийг богино хугацаат гэж ангилна.
85. Байгууллага нь урт хугацаат зээлийн гэрээний нөхцлийг тайлант үеийн эцсээр эсвэл түүнээс өмнө зөрчсөн бөгөөд үүний улмаас өр төлбөрийг анхны шаардлагаар төлөхөөр болсон тохиолдолд хэдийгээр зээлдүүлэгч нь тэрхүү зөрчлийн улмаас төлбөр хийх шаардлага гаргахгүй гэдгээ тайлант үеийн эцсээс хойш боловч санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрөхөөс өмнө мэдэгдсэн байлаа ч гэсэн уг өр төлбөрийг богино хугацаат гэж ангилна. Тайлант үеийн эцсээр байгууллага нь уг өдрөөс хойш наад зах нь 12 сарын хугацаанд төлбөр барагдуулалтыг хойшлуулах нөхцөлт бус (үл маргах) эрхгүй болсон учраас тэрхүү өр төлбөрийг богино хугацаат гэж ангилна.
86. Гэвч зээлдүүлэгч нь тайлант үеийн эцсээс хойш наад зах нь 12 сарын дараа дуусах чөлөөлтийн хугацаа олгохоор тухайн тайлант үеийн эцсээр зөвшөөрсөн бөгөөд уг хугацааны дотор байгууллага нь зөрчлийг арилгах

ба энэ явцад зээлдүүлэгч нь нэн даруй төлбөр хийхийг шаардахгүй болсон тохиолдолд байгууллага нь өр төлбөрийг урт хугацаат гэж ангилна.

87. Богино хугацаат өр төлбөр гэж ангилсан зээлтэй холбоотойгоор хэрэв тайлант үеийн эцсийн өдөр ба санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрсөн өдрийн хоорондох хугацаанд дараах үйл явдал гарч тохиолдсон бол УСНББОУС 14 *Тайлант Үеийн Дараах Үйл Явдал*-ын дагуу тэдгээр үйл явдлыг үл тохируулах үйл явдал гэж тодруулна:
- (а) урт хугацаагаар дахин санхүүжилт хийх;
  - (б) урт хугацаат зээлийн гэрээний зөрчлийг арилгах; ба
  - (в) урт хугацаат зээлийн гэрээний зөрчлийг арилгахын тулд тайлант үеийн эцсээс хойш наад зах нь 12 сарын хугацааны дараа дуусах чөлөөлөлтийн хугацааг зээлдүүлэгч олгох.

*Санхүүгийн байдлын тайланд толилуулах мэдээлэл*

88. **Санхүүгийн байдлын тайлан хамгийн наад зах нь дараах дүнгүүдийг илэрхийлэх мөрийн зүйлсийг агуулсан байна:**
- (а) **Үндсэн хөрөнгө;**
  - (б) **Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө**
  - (в) **Биет бус хөрөнгө;**
  - (г) **Санхүүгийн хөрөнгө ((д), (ж), (и), (к)-гийн дагуу харуулсан дүнгээс бусад);**
  - (д) **Өмчийн аргыг ашиглан тайлагнасан хөрөнгө оруулалт;**
  - (е) **Бараа материал;**
  - (ж) **Арилжааны бус ажил гүйлгээний нөхөн төлбөр (татвар ба шилжүүлэг);**
  - (и) **Арилжааны ажил гүйлгээний авлага;**
  - (к) **Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө;**
  - (л) **Татвар ба шилжүүлгийн өглөг;**
  - (м) **Арилжааны ажил гүйлгээний өглөг;**
  - (н) **Нөөц сан;**
  - (о) **Санхүүгийн өр төлбөр; ((л), (м), (н)-гийн дагуу харуулсан дүнгээс бусад);**
  - (п) **Цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүнд толилуулсан хяналтын бус хувь оролцоо; ба**
  - (р) **Хяналт тавигч байгууллагын эздэд хамаарах цэвэр хөрөнгө/өмч.**

89. **Ийм толилуулга нь тухайн байгууллагын санхүүгийн байдлыг ойлгоход хамааралтай тохиолдолд нэмэлт мөрийн зүйлс, гарчиг ба дэд дүнгүүдийг санхүүгийн байдлын тайланд толилуулна.**
90. Мөрийн зүйлсийг толилуулах дараалал буюу загварыг энэхүү Стандарттаар тодорхойлж заагаагүй. Санхүүгийн байдлын тайланд тусдаа толилуулах хэрэгтэй гэдгийг илэрхийлэх эрс өөр шинж төрөл буюу чиг үүрэг бүхий зүйлсийн жагсаалтыг 88-р параграфт харуулсан. Үлгэрчилсэн загварыг энэ Стандартын Хэрэгжүүлэх заавар удирдамжинд тусгасан. Үүнээс гадна:
- (a) хэрэв тухайн мөрийн зүйл эсвэл нэгтгэн нийлүүлсэн ижил төсөөтэй мөрийн зүйлсийн хэмжээ, шинж төрөл буюу чиг үүрэг нь уг байгууллагын санхүүгийн байдлыг ойлгоход хамааралтай бол тэдгээрийн хувьд тусдаа мөрийн зүйлийг оруулна; ба
  - (б) байгууллагын санхүүгийн байдлыг ойлгоход хамааралтай мэдээллээр хангахын тулд уг ашиглаж буй мөрийн зүйлсийн нэр, тэдгээрийн дэс дараалал ба ижил төсөөтэй мөрийн зүйлсийн нэгтгэн нийлүүлэлтийг тухайн байгууллагын болон түүний ажил гүйлгээний шинж төрлийн дагуу өөрчилж болно.
91. Нэмэлт мөрийн зүйлсийг тусад нь толилуулах эсэх шүүн тунгаалтыг дараах зүйлсийн үнэлгээнд үндэслэн хийнэ:
- (a) хөрөнгийн шинж төрөл ба хөрвөх чадвар;
  - (б) тухайн байгууллагын хүрээн дэх уг хөрөнгийн чиг үүрэг; ба
  - (в) өр төлбөрийн дүн, төрөл, хугацаа.
92. Хөрөнгийн өөр өөр ангиудын хувьд хэмжилтийн ялгаатай сууриудыг хэрэглэх нь тэдгээрийн шинж төрөл буюу чиг үүрэг өөр гэдгийг илэрхийлдэг тул тэдгээрийг тусдаа мөрийн зүйлс байдлаар толилуулна. Жишээлбэл; үндсэн хөрөнгийн өөр өөр ангиудыг УСНББОУС 17, *Үндсэн Хөрөнгө*-ийн дагуу өртгөөр эсвэл дахин үнэлсэн дүнгээр бүртгэж болох юм.

*Санхүүгийн байдлын тайланд эсвэл тодруулгад толилуулах мэдээлэл*

93. **Байгууллага нь тухайн толилуулсан мөрийн зүйлсийн цаашдын дэлгэрэнгүй дэд ангиллуудыг өөрийн үйл ажиллагаанд тохиромжтой арга хэлбэрээр ангилж, санхүүгийн байдлын тайлан эсвэл тодруулгын аль нэгэнд толилуулна.**
94. Дэд ангиллуудад дэлгэрэнгүй харуулах зэрэг хэмжээ нь УСНББОУС-ын шаардлага, түүнчлэн тухайн хамаарах дүнгийн хэмжээ, шинж төрөл, чиг үүргээс хамаарна. Дэд ангиллын суурийг тогтооходоо 91-р параграфт заасан хүчин зүйлсийг мөн харгалзан үзнэ. Толилуулга нь мөрийн зүйл тус бүрийн хувьд ялгаатай байна. Тухайлбал;
- (a) Үндсэн хөрөнгийн зүйлсийг УСНББОУС 17-гийн дагуу ангиудад салган задлана;

- (б) Хэрэглэгчдээс авах авлага, татварын болон бусад арилжааны бус орлогын авлага, холбоотой талуудаас авах авлага, урьдчилж төлсөн төлбөр болон бусад дүнгүүдээр авлагыг салган задлана;
  - (в) Бараа материалыг УСНББОУС 2 *Бараа Материал*-ын дагуу бараа, үйлдвэрлэлийн хангамжийн зүйлс, материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн гэх мэт ангиллуудаар салган задлана;
  - (г) Татвар ба шилжүүлгийн өглөгийг татварын буцаалтын өглөг, шилжүүлгийн өглөг, эдийн засгийн нэгдмэл байгууллагын бусад гишүүдэд төлөх өглөг гэдгээр салган задална;
  - (д) Нөөц санг ажилтны тэтгэмжийн болон бусад зүйлсийн нөөцийн сан гэдгээр салган задлана;
  - (е) Цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг буюу алдагдал, нөөц сан гэх мэт ангиллуудаар салган задлана.
95. **Хэрэв байгууллага нь хувьцаат капиталгүй бол цэвэр хөрөнгө/өмчийг санхүүгийн байдлын тайланд эсвэл тодруулгад толилуулах бөгөөд дараах зүйлсийг тус тусад нь харуулна:**
- (а) **Хувь нийлүүлсэн хөрөнгө, энэ нь тухайн тайлангийн өдрөөрх эздийн оруулсан хувь оролцооноос эздэд олгосон хуваарилалтыг хассан, нийт хуримтлагдсан дүн байна;**
  - (б) **Хуримтлагдсан ашиг буюу алдагдал;**
  - (в) **Нөөц сан, үүнд: цэвэр хөрөнгө/өмчийн хүрэн дэх нөөц сан тус бүрийн шинж төрөл ба зорилгын талаархи тайлбар тодорхойлолт; ба**
  - (г) **Хяналтын бус хувь оролцоо.**
- 95А. **Хэрэв байгууллага нь дараах зүйлсийг санхүүгийн өр төлбөр ба цэвэр хөрөнө/өмчийн хооронд дахин ангилсан бол ангилал тус бүрд эсвэл ангилал тус бүрээс (санхүүгийн өр төлбөр эсвэл цэвэр хөрөнгө/өмч) дахин ангилагдсан дүн, тухайн дахин ангиллын хугацаа ба учир шалтгааныг тодруулна:**
- (а) **Өмчийн хэрэглүүр гэж ангилагдсан, буцаах эрхтэй санхүүгийн хэрэглүүр; эсвэл**
  - (б) **Зөвхөн татан буугдах үед байгууллагын цэвэр хөрөнгөөс хувь тэнцүүлэн нөгөө талд олгох үүрийг тухайн байгууллагад хүлээлгэдэг бөгөөд өмчийн хэрэглүүр гэж ангилагдсан хэрэглүүр.**
96. Улсын секторын олон байгууллага нь хувьцаат капиталгүй боловч тухайн байгууллагыг зөвхөн улсын секторын өөр нэг байгууллага хянаж байдаг. Ийм байгууллагын цэвэр хөрөнгө/өмч дэх засгийн газрын хувь оролцооны шинж төрөл нь хувь нийлүүлсэн капитал, түүнчлэн тухайн байгууллагын үйл ажиллагааны үр дүнд хамааруулж болох цэвэр хөрөнгө/өмчийг тусган

илэрхийлэх уг байгууллагын хуримтлагдсан ашиг алдагдал, нөөцийн хослол хэлбэртэй байх магадлалтай юм.

97. Зарим тохиолдолд байгууллагын цэвэр хөрөнгө/өмчийн хувьд хяналтын бус хувь оролцоогүй байж болно. Жишээлбэл; нийт засгийн газрын түвшинд, эдийн засгийн нэгдмэл байгууллага нь хэсэгчлэн хувьчлагдсан, бизнесийн зорилготой, улсын секторын байгууллагыг өөртөө агуулсан байж болох юм. Иймээс уг байгууллагын цэвэр хөрөнгө/өмчид санхүүгийн хувь оролцоотой, хувийн хэвшлийн хувьцаа эзэмшигчидтэй байж болно.
98. **Байгууллага нь хувьцаат капиталтай тохиолдолд 95-р параграфт заасан тодруулгаас гадна дараах зүйлсийг санхүүгийн байдлын тайланд эсвэл тодруулгад толилуулна:**
- (а) **Хувьцаат капиталын анги тус бүрийн хувьд:**
- (1) зөвшөөрөгдсөн хувьцааны тоо;
  - (2) гаргасан ба бүрэн төлөгдсөн хувьцааны тоо, гаргасан боловч бүрэн төлөгдөөгүй хувьцааны тоо;
  - (3) нэгж хувьцааны нэрлэсэн үнэ эсвэл хувьцаа нь нэрлэсэн үнэгүй талаархи заалт;
  - (4) тайлант үеийн эхэнд болон эцэст эргэлтэнд байгаа хувьцааны тооны тохируулга;
  - (5) хувьцааны тухайн ангид хамаарах эрх, давуу эрх, хязгаарлалтууд, үүн дотроо ногдол ашиг хуваарилах ба капиталыг буцаан төлөх талаархи хязгаарлалтууд;
  - (6) тухайн байгууллагын хувьд уг байгууллага өөрөө, эсвэл түүний охин буюу хараат байгууллагуудын эзэмшиж буй хувьцаа;
  - (7) опцион болон хувьцаа борлуулах гэрээний дагуу гаргахаар нөөцөлсөн хувьцаа, үүн дотроо түүний нөхцөл ба дүн;
- (б) **Цэвэр хөрөнгө/ өмчийн хүрээнд хамаарах нөөц сан тус бүрийн шинж төрөл ба зориулалтын талаархи тайлбар тодорхойлолт.**

## Санхүүгийн үр дүнгийн тайлан

*Тайлант үеийн ашиг, алдагдал*

99. **УСНББОУС-д өөрөөр шаардснаас бусад тохиолдолд, тайлант үед хүлээн зөвшөөрсөн орлого, зардлын бүх зүйлсийг ашиг, алдагдалд тусгана.**
100. Тайлант үед хүлээн зөвшөөрсөн орлого, зардлын бүх зүйлсийг ашиг, алдагдалд ерөнхийдөө тусгадаг. Үүнд нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтийн үр нөлөө хамаарна. Гэвч тодорхой нэг зүйлсийг тайлант үеийн ашиг, алдагдалд оруулахгүй байх нөхцөл байдалтай байж

болно. Ийм хоёр нөхцлийг УСНББОУС 3-д заасан. Үүнд: алдааны залруулга ба нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн үр нөлөө.

101. Энэ Стандартад заасан орлого, зардлын тодорхойлолтыг хангаж болох боловч ашиг, алдагдалд ихэвчлэн оруулдаггүй зүйлсийг өөр бусад УСНББОУС-д заасан байдаг. Жишээлбэл; дахин үнэлгээний нэмэгдэл, үүнд: (а) гадаад үйл ажиллагааны санхүүгийн тайлангийн хөрвүүлэлтээс үүссэн олз ба гарз (УСНББОУС 4-ийг үзнэ үү), (б) борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгийн дахин хэмжилтээс үүссэн олз ба гарз (санхүүгийн хөрөнгийн хэмжилтийн талаархи заавар удирдамжийг УСНББОУС 29-өөс үзэж болно).

*Санхүүгийн үр дүнгийн тайланд толилуулах мэдээлэл*

102. **Санхүүгийн үр дүнгийн тайлан нь тухайн тайлант үеийн хувьд хамгийн наад зах нь дараах дүнгүүдийг толилуулах мөрийн зүйлсийг агуулсан байна:**
- (а) Орлого;
  - (б) Санхүүгийн зардал;
  - (в) Өмчийн арга ашиглан тайлагнасан хараат байгууллага ба хамтарсан үйлдвэрийн ашиг, алдагдал дахь хувь хэмжээ;
  - (г) Зогсоосон үйл ажиллагаанд хамаарах хөрөнгийн данснаас хасалт буюу өр төлбөрийн барагдуулалтаар хүлээн зөвшөөрсөн татварын өмнөх олз, гарз; ба
  - (д) Ашиг, алдагдал.
103. **Дараах зүйлсийг тайлант үеийн ашиг, алдагдлын хуваарилалт байдлаар санхүүгийн үр дүнгийн тайланд толилуулна:**
- (а) Хяналтын бус хувь оролцоонд хамаарах ашиг, алдагдал; ба
  - (б) Хяналт тавигч байгууллагын эздэд хамаарах ашиг, алдагдал.
104. **Ийм толилуулга нь тухайн байгууллагын санхүүгийн үр дүнг ойлгоход хамааралтай тохиолдолд нэмэлт мөрийн зүйлс, гарчиг ба дэд дүнгүүдийг санхүүгийн үр дүнгийн тайланд толилуулна.**
105. Байгууллагын янз бүрийн үйл ажиллагаа, ажил гүйлгээ, бусад үйл явдлуудын үр нөлөө нь үйлчилгээ үзүүлэх үүргээ биелүүлэх түүний чадвар, боломжид үзүүлэх нөлөөллийн хувьд өөр өөр байдаг учраас санхүүгийн үр дүнгийн бүрэлдэхүүн хэсгүүдийг толилуулах нь тухайн хүрсэн санхүүгийн үр дүнг ойлгох ба ирээдүйн үр дагаврын талаар прогноз хийхэд туслалцаа үзүүлдэг. Үр дүнгийн элементүүдийг тайлбарлахад шаардлагатай байх тохиолдолд санхүүгийн үр дүнгийн тайланд нэмэлт мөрийн зүйлс оруулах бөгөөд ашигласан мөрийн зүйлсийн нэр, тэдгээр зүйлсийг байрлуулах дэс дарааллыг өөрчилдөг. Харгалзах хүчин зүйлсэд материаллаг байдал, түүнчлэн орлого, зардлын зүйлсийн шинж төрөл ба чиг үүрэг хамаарна. 48-



р параграфт заасан шалгуур хангагдахаас бусад тохиолдолд орлого, зардлын зүйлсийг хооронд нь хааж, цэвэр дүнгээр харуулахгүй.

*Санхүүгийн үр дүнгийн тайланд эсвэл тодруулгад толилуулах мэдээлэл*

106. **Орлого, зардлын зүйлс нь материаллаг байх тохиолдолд тэдгээрийн шинж төрөл ба дүнг тусад нь толилуулна.**
107. Орлого, зардлын зүйлсийг тусад нь толилуулахыг шаарддаг нөхцөл байдалд дараах зүйлс хамаарна:
- (а) Бараа материалыг цэвэр боломжит үнэ цэнэ хүртэл, үндсэн хөрөнгийг түүний нөхөгдөх дүн эсвэл нөхөгдөх үйлчилгээний дүнгийн аль тохиромжтой хүртэл бууруулалт, түүнчлэн тэдгээр бууруулалтын буцаалт;
  - (б) Байгууллагын үйл ажиллагааны бүтцийн өөрчлөлт ба ийм бүтцийн өөрчлөлтийн зардлын аливаа нөөцийн буцаалт;
  - (в) Үндсэн хөрөнгө данснаас хасалт;
  - (г) Хөрөнгө оруулалтын хувьчлал буюу бусад данснаас хасалт;
  - (д) Зогсоосон үйл ажиллагаа;
  - (е) Зарга маргааны шийдвэрлэлт; ба
  - (ж) Нөөц сангийн бусад буцаалт.
108. **Байгууллага нь өөрийн үйл ажиллагаанд тохиромжтой арга хэлбэрээр ангилсан, нийт орлогын дэд ангиллуудыг санхүүгийн үр дүнгийн тайлан эсвэл тодруулгын аль нэгэнд толилуулна.**
109. **Аль нь үнэн зөв илэрхийлэлт ба илүү хамааралтай мэдээллээр хангадаг эсэхээс шалтгаалан зардлын шинж төрөлд эсвэл тухайн байгууллагын хүрээн дэх зардлын чиг үүрэгт үндэслэсэн ангиллыг ашигласнаар уг байгууллага нь зардлын задаргаа шинжилгээг санхүүгийн үр дүнгийн тайланд эсвэл тодруулгад толилуулна.**
110. Байгууллага нь 109-р параграфт дурдсан шинжилгээг санхүүгийн үр дүнгийн тайланд толилуулахыг дэмжинэ.
111. Тайлагнагч байгууллагын тодорхой хөтөлбөр, үйл ажиллагаа буюу бусад холбогдох сегментийн зардал ба зардлын нөхөлтийг онцлон илэрхийлэхийн тулд зардлуудыг дэд ангилалд хуваадаг. Энэ шинжилгээг хоёр арга замын аль нэгээр хийж болно.
112. Шинжилгээний эхний хэлбэр нь 'зардлын шинж төрөл'-ийн арга юм. Зардлуудыг тэдгээрийн шинж төрлийн (жишээлбэл; элэгдэл, материалын худалдан авалт, тээврийн зардал, ажилтны тэтгэмж, зар сурталчилгааны зардал) дагуу санхүүгийн үр дүнгийн тайланд нэгтгэн тусгах ба тухайн байгууллагын хүрээн дэх чиг үүргээр тэдгээр зардлыг дахин хуваарилахгүй. Зардлуудыг чиг үүргийн ангиллаар хуваарилах шаардлагагүй учраас энэ

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЛИЛУУЛГА

арга нь хялбар байж болох юм. Зардлын шинж төрлийн аргыг хэрэглэн хийсэн ангиллын жишээг доор харуулав:

Орлого		X
Ажилтны тэтгэмжийн зардал	X	
Элэгдэл ба хорогдуулгын зардал	X	
Бусад зардал	X	
Нийт зардал	<hr/>	(X)
Ашиг		<hr/> X <hr/>

113. Шинжилгээний хоёр дахь хэлбэр нь 'зардлын чиг үүрэг'-ийн арга бөгөөд тэдгээрийг зарцуулсан хөтөлбөр буюу зорилгын дагуу зардлыг ангилдаг. Энэ арга нь шинж төрлөөр хийсэн зардлын ангилалтай харьцуулахад хэрэглэгчдийг илүү их хамааралтай мэдээллээр хангадаг боловч өртөг зардлуудыг чиг үүргээр хуваарилахдаа тохиолдлын шинжтэй хуваарилалт ашиглах, субъектив дүгнэлт хийх шаардлагатай байж болох юм. Зардлын чиг үүргийн аргыг ашиглан хийсэн ангиллын жишээг доор харуулав:

Орлого		X
Зардал:		
Эрүүл мэндийн зардал		(X)
Боловсролын зардал		(X)
Бусад зардал		(X)
Ашиг		<hr/> X <hr/>

114. Байгууллагын гүйцэтгэж буй үндсэн чиг үүрэгтэй холбоотой зардлуудыг тусад нь харуулна. Энэ жишээнд байгууллага нь эрүүл мэндийн болон боловсролын үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй байна. Байгууллага нь эдгээр чиг үүрэг тус бүрийн хувьд зардлын мөрийн зүйлсийг толилуулна.

115. **Зардлыг чиг үүргээр ангилж буй байгууллага нь зардлын шинж төрлийн, үүн дотроо элэгдэл ба хорогдуулгын зардал, ажилтны тэтгэмжийн зардлын талаархи нэмэлт мэдээллийг толилуулна.**

116. Зардлын чиг үүргийн арга эсвэл зардлын шинж төрлийн аргын сонголт нь түүхэн болон зохицуулалтын хүчин зүйлс, тухайн байгууллагын шинж төрлөөс хамаарна. Эдгээр өртөг зардал нь тухайн байгууллагын гарц бүтээгдэхүүнээс шууд эсвэл шууд бусаар хамааран өөрчлөгдөж болно гэдгийг энэ хоёр аргын аль аль нь харуулдаг. Янз бүрийн байгууллагуудын хувьд эдгээр арга нь өөр өөрийн гэсэн давуу талтай байдаг учраас энэхүү Стандарт нь хамгийн их хамааралтай ба үнэн зөв илэрхийлэх толилуулгын

аргыг сонгож, хэрэглэхийг удирдлагаас шаарддаг. Гэвч зардлын шинж төрлийн талаархи мэдээлэл нь ирээдүйн мөнгөн гүйлгээг урьдчилан таамаглахад ач холбогдолтой тул зардлын чиг үүргийн ангиллыг ашиглах тохиолдолд нэмэлт тодруулга хийх шаардлагатай байдаг. 115-р параграфт дурдсан 'ажилтны тэтгэмж' нь УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-д тодорхойлсонтой ижил утгатай байна.

117. **Байгууллага нь эздэд ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт олгодог бөгөөд хувьцаат капиталтай тохиолдолд уг байгууллага нь тухайн тайлант үеийн туршид эздэд олгосон хуваарилалт байдлаар хүлээн зөвшөөрсөн ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт болон нэгж хувьцаанд ногдох холбогдох дүнг санхүүгийн үр дүнгийн тайланд эсвэл цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд эсвэл тодруулгад толилуулна.**

### **Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

118. **Байгууллага нь цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд дараах зүйлсийг харуулснаар уг тайланг толилуулна:**

- (a) Тайлант үеийн ашиг, алдагдал;
- (б) Бусад Стандартаар шаардсанчлан, цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн тухайн тайлант үеийн орлого, зардлын зүйл тус бүр болон тэдгээрийн нийт дүн;
- (в) Тухайн тайлант үеийн нийт орлого ба зардал (дээрх (a) ба (б)-гийн нийлбэр байдлаар тооцоолсон), үүнд: уг хяналт тавигч байгууллагын эздэд болон хяналтын бус хувь оролцоонд хамаарах нийт дүнгүүдийг тусад нь харуулах; ба
- (г) Тусдаа толилуулсан цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн хувьд УСНББОУС 3-ын дагуу хүлээн зөвшөөрсөн нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн үр нөлөө ба алдааны засварлалт.

119. **Байгууллага нь мөн дараах зүйлсийг цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд эсвэл тодруулгад толилуулна:**

- (a) Эздэд болохын хувьд тэдний бүрэн эрхийн хүрээнд эзэдтэй хийсэн ажил гүйлгээний дүн, үүнд эздэд олгосон хуваарилалтуудыг тусад нь харуулна;
- (б) Тайлант үеийн эхэн ба эцэс дэх хуримтлагдсан ашиг, алдагдлын үлдэгдэл, тухайн тайлант үеийн турш дахь хуримтлагдсан ашиг, алдагдлын өөрчлөлт; ба
- (в) Цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тусдаа толилуулдаг тохиолдолд цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн дансны үнийн тайлант үеийн эхний болон эцсийн тохируулга, өөрчлөлт нэг бүрийг тусад нь толилуулна.

120. Хоёр тайлангийн өдрийн хооронд байгууллагын цэвэр хөрөнгө/өмчид орсон өөрчлөлт нь тухайн тайлант үеийн турш дахь түүний цэвэр хөрөнгийн өсөлт эсвэл бууралтыг илэрхийлнэ.
121. Тайлант үеийн туршид цэвэр хөрөнгө/өмчид орсон нийт өөрчлөлт нь тухайн тайлант үеийн ашиг, алдагдлын нийт дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт байдлаар шууд хүлээн зөвшөөрсөн бусад орлого ба зардлыг эзэд болохын хувьд тэдний бүрэн эрхийн хүрээнд эздийн оруулсан аливаа хувь оролцоо болон тэдэнд олгосон хуваарилалтын хамт харуулна.
122. Эздийн оруулсан хувь оролцоо ба тэдэнд олгосон хуваарилалт нь эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх хоёр байгууллагын хоорондох шилжүүлгийг (жишээлбэл; эзэд болохын хувьд өөрийн бүрэн эрхийн хүрээнд засгийн газраас өөрийн агентлагт олгосон шилжүүлгийг) агуулсан байдаг. Эзэд болохын хувьд тэдний бүрэн эрхийн хүрээнд эздээс өөрийн хяналтанд буй байгууллагуудад оруулсан хувь оролцоо нь цэвэр хөрөнгө/өмчийн эрх хэлбэрээр тухайн байгууллага дахь түүний үлдэх хувь оролцоог илт нэмэгдүүлэх зөвхөн тийм тохиолдолд уг хувь оролцоог цэвэр хөрөнгө/өмчийн шууд тохируулга байдлаар хүлээн зөвшөөрнө.
123. Бусад УСНББОУС нь өөрөөр шаарддагаас бусад тохиолдолд энэ Стандарт нь тайлант үед хүлээн зөвшөөрсөн орлого, зардлын бүх зүйлсийг ашиг, алдагдалд тусган оруулахыг шаарддаг. Бусад УСНББОУС нь зарим зүйлсийг (дахин үнэлгээний нэмэгдэл ба бууралт, гадаад валютын тодорхой ханшийн зөрүү гэх мэт) цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт байдлаар шууд хүлээн зөвшөөрөхийг шаарддаг. Хоёр тайлангийн өдрийн хооронд байгууллагын санхүүгийн байдалд орсон өөрчлөлтийг үнэлэхдээ орлого, зардлын бүх зүйлсийг харгалзан үзэх нь чухал ач холбогдолтой учраас байгууллагын нийт орлого, зардлыг, үүн дотроо цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрдөг орлого, зардлыг тусган илэрхийлэх цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланг толилуулахыг энэхүү Стандартаар шаарддаг.
124. Өөр УСНББОУС-ын шилжилтийн нөхцөл нь өөрөөр зааснаас бусад тохиолдолд УСНББОУС 3 нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг тусгахын тулд практик боломжтой хэмжээгээр буцаах горимоор тохируулга хийхийг шаарддаг. Мөн алдааг залруулах дахин тайлагналыг практик боломжтой хэмжээгээр буцаах горимоор гүйцэтгэхийг УСНББОУС 3-аар шаардсан байдаг. УСНББОУС нь цэвэр хөрөнгө/өмчийн өөр нэг бүрэлдэхүүн хэсэгт буцаах горимоор тохируулга хийхийг шаардснаас бусад тохиолдолд, буцаах горимоор хийх тохируулга ба буцаах горимоор хийх дахин тайлагналыг хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдэлд тусгана. Цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрд хийх нийт тохируулгыг нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөс үүссэн ба алдааны залруулгаас үүссэн гэдгээр цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд тус тусад нь толилуулахыг 118(г) параграфтаар шаардсан байдаг. Эдгээр тохируулгыг өмнөх тайлант үе бүрд болон тухайн тайлант үеийн эхэнд толилуулна.

125. Цэвэр хөрөнгө/өмчийн элемент тус бүрийн эхний ба эцсийн үлдэгдлийг тохируулах багана хэлбэрийг ашигласнаар 118 болон 119-р параграфын шаардлагуудыг хангаж болох юм. Өөр нэг хувилбар нь зөвхөн 118-р параграфт заасан зүйлсийг цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд толилуулах явдал юм. 119-р параграфт дурдсан зүйлсийг энэхүү арга хандлагын дагуу тодруулгад тусгаж харуулна.

## **Мөнгөн гүйлгээний тайлан**

126. Мөнгөн гүйлгээний мэдээлэл нь (а) мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө бий болгох уг байгууллагын чадвар, боломж болон (б) тэдгээр мөнгөн гүйлгээг ашиглах тухайн байгууллагын хэрэгцээ шаардлагыг үнэлэх суурь үндэслэлээр санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийг хангадаг. УСНББОУС 2 нь мөнгөн гүйлгээний тайлангийн толилуулга болон холбогдох тодруулгын шаардлагуудыг тогтоодог.

## **Тодруулга**

### *Бүтэц*

127. **Тодруулга нь:**
- (а) **Санхүүгийн тайлан бэлтгэлтийн суурь болон 132-139-р параграфт заасан, ашигласан нягтлан бодох бүртгэлийн тусгай бодлогын талаархи мэдээллийг толилуулна;**
  - (б) **Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч УСНББОУС-уудаар шаарддаг мэдээллийг тодруулна; ба**
  - (в) **Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана.**
128. **Тодруулгыг практик боломжтой хэмжээгээр системчилсэн арга маягаар толилуулна. Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангийн мөрийн зүйл нэг бүрийг тодруулга дахь аливаа холбогдох мэдээлэлтэй харилцан лавлагаа үүсгэнэ.**
129. Санхүүгийн тайланг ойлгох ба тэдгээрийг бусад байгууллагуудын санхүүгийн тайлантай зэрэгцүүлэхэд хэрэглэгчдэд туслахын тулд тодруулгыг ихэвчлэн дараах эрэмбэ дарааллаар толилуулна:
- (а) УСНББОУС-тай нийцсэн тухай мэдэгдэл (28-р параграфыг үзнэ үү);
  - (б) Мөрдсөн нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын тойм (132-р параграфыг үзнэ үү);

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЛИЛУУЛГА

- (в) Санхүүгийн тайлан болон мөрийн зүйлс нэг бүрийг толилуулсан дэс дарааллын дагуу санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулсан зүйлсийн талаархи дэмжих мэдээлэл; болон
  - (г) Бусад тодруулга, үүнд:
    - (1) Болзошгүй өр төлбөр (УСНББОУС 19-ийг үзнэ үү) ба хүлээн зөвшөөрөөгүй гэрээний хариуцлага; ба
    - (2) Санхүүгийн бус тодруулгууд, жишээлбэл; тухайн байгууллагын санхүүгийн эрсдлийн удирдлагын зорилтууд ба бодлогууд (УСНББОУС 30-ийг үзнэ үү).
130. Тодруулгад хамаарах тодорхой зүйлсийн эрэмбэ дарааллыг зарим тохиолдолд өөрчлөх шаардлагатай буюу ингэж өөрчлөх нь зохистой байж болно. Жишээлбэл; ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн талаархи мэдээлэл нь санхүүгийн үр дүнгийн тайлантай, харин санхүүгийн хэрэглүүрийн дуусгавар болох хугацааны талаархи мэдээлэл нь санхүүгийн байдлын тайлантай холбоотой боловч тэдгээрийг нэгтгэн нийлүүлж болох юм. Гэхдээ тодруулгын системчилсэн бүтцийг практик боломжтой хэмжээгээр хадгална.
131. Санхүүгийн тайлан бэлтгэлтийн суурь болон нягтлан бодох бүртгэлийн тусгай бодлогын талаархи мэдээллээр хангах тодруулгыг тухайн санхүүгийн тайлангийн тусдаа бүрэлдэхүүн хэсэг байдлаар толилуулж болно.

### *Нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулга*

132. **Байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын тоймд дараах зүйлсийг тодруулна:**
- (а) **Санхүүгийн тайланг бэлтгэхдээ ашигласан хэмжилтийн суурь (буюу сууриуд);**
  - (б) **Аль нэг УСНББОУС-ын шилжилтийн аливаа нөхцлийг тухайн байгууллага даган мөрдсөн хэмжээ; ба**
  - (в) **Санхүүгийн тайланг ойлгоход хамааралтай бөгөөд ашигласан нягтлан бодох бүртгэлийн бусад бодлого.**
133. Санхүүгийн тайланг бэлтгэхдээ үндэслэсэн суурь нь хэрэглэгчдийн шинжилгээнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг учраас тухайн санхүүгийн тайланд ашигласан хэмжилтийн суурь буюу сууриудыг (тухайлбал; түүхэн өртөг, одоогийн өртөг, цэвэр боломжит үнэ цэнэ, бодит үнэ цэнэ, нөхөгдөх дүн буюу нөхөгдөх үйлчилгээний дүн) хэрэглэгчдэд мэдээлэх нь чухал ач холбогдолтой юм. Санхүүгийн тайланд нэгээс олон хэмжилтийн суурь ашигласан, тухайлбал, хөрөнгийн тухайн тодорхой ангиудыг дахин үнэлсэн тохиолдолд хэмжилтийн суурь нэг бүрийг ашигласан уг хөрөнгө ба өр төлбөрийн ангиудыг заан илэрхийлэх нь хангалттай байдаг.

134. Нягтлан бодох бүртгэлийн тодорхой нэг бодлогыг тодруулах эсэхийг шийдвэрлэхдээ, удирдлага нь уг тайлагнасан санхүүгийн үр дүн болон санхүүгийн байдалд тэдгээр ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдал хэрхэн тусгагдсан гэдгийг хэрэглэгч нар ойлгоход тухайн тодруулга туслах эсэхийг харгалзан үздэг. Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг УСНББОУС дахь зөвшөөрөгдсөн сонголтот хувилбаруудаас сонгож авсан тохиолдолд уг нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаархи тодруулга нь хэрэглэгчдэд илүү чухал ач холбогдолтой байдаг. Жишээлбэл; байгууллага нь өөрийн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хувьд бодит үнэ цэнэ эсвэл өртгийн загварын алийг нь хэрэглэсэн эсэх талаар тодруулга хийнэ (УСНББОУС 16, *Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө*-ийг үзнэ үү). Зарим УСНББОУС нь тодорхой нэг нягтлан бодох бүртгэлийн бодлогын, үүн дотроо тэдгээр Стандартуудаар зөвшөөрсөн янз бүрийн бодлогуудаас удирдлагын хийсэн сонголтын талаар тодруулахыг шаарддаг. Тухайлбал; УСНББОУС 17 нь үндсэн хөрөнгийн ангиудын хувьд ашигласан хэмжилтийн сууриудын талаар тодруулга хийхийг шаарддаг. УСНББОУС 5, *Зээлийн Өртөг* нь зээлийн өртгийг зардал гэж нэн даруй хүлээн зөвшөөрдөг эсвэл шалгуур хангах хөрөнгийн өртгийн нэг хэсэг байдлаар капиталжуулдаг эсэх талаар тодруулга хийхийг шаарддаг.
135. Байгууллага бүр нь өөрийн үйл ажиллагааны шинж төрөл болон тухайн төрлийн байгууллагын хувьд тодруулна гэж түүний санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн хүлээж болох бодлогуудыг харгалзан үздэг. Жишээлбэл; татвар, хандив болон бусад төрлийн арилжааны бус орлогын хүлээн зөвшөөрөлтийн талаархи нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодруулна гэж улсын секторын байгууллагуудаас хүлээдэг. Байгууллага нь мэдэгдэхүйц хэмжээний гадаад үйл ажиллагаатай буюу гадаад валютаар хийгдэх мэдэгдэхүйц их ажил гүйлгээтэй тохиолдолд гадаад валютын ханшийн зөрүүгийн олз, гарзын хүлээн зөвшөөрөлтийн талаархи нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулгыг хийнэ гэж хүлээдэг. Улсын секторын нэгдэл хийсэн тохиолдолд гүүдвилл болон хяналтын бус хувь оролцоог хэмжихдээ ашигласан бодлогуудыг тодруулна.
136. Тухайн тайлант үе болон өмнөх тайлант үеүдийн дүнгүүд материаллаг бус боловч уг байгууллагын үйл ажиллагааны шинж төрлөөс хамааран нягтлан бодох бүртгэлийн бодлого нь мэдэгдэхүйц ач холбогдолтой байж болно. УСНББОУС-уудаар тусгайлан шаардаагүй боловч УСНББОУС 3-ын дагуу сонгож, мөрддөг нягтлан бодох бүртгэлийн мэдэгдэхүйц бодлого нэг бүрийг тодруулах нь мөн тохиромжтой байдаг.
137. **Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүнгүүдэд хамгийн их мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх уг байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдөхдөө удирдлагын хийсэн шүүн тунгаалтыг тухайн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын тоймд эсвэл бусад тодруулгад, тооцоололтой холбоотой шүүн тунгаалтаас (140-р параграфыг үзнэ үү) тусад нь тодруулна.**

138. Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдөхдөө удирдлага нь санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүнгүүдэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлж болох тооцооллолтой холбоотойгоос өөр бусад, янз бүрийн шүүн тунгаалтуудыг хийдэг. Жишээлбэл; удирдлага нь дараах зүйлсийг тодорхойлохдоо шүүн тунгаалт хийдэг:
- Хөрөнгө нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө мөн эсэх;
  - Тухайн зориулагдсан хөрөнгийн ашиглалттай холбоотой бараа, үйлчилгээгээр хангах хэлцэл нь түрээс мөн эсэх;
  - Барааны тухайн тодорхой борлуулалт нь мөн чанарын хувьд санхүүжилтийн хэлцэл мөн, ингэснээр орлого үүсэхэд хүргэхгүй эсэх;
  - Тайлагнагч байгууллага ба бусад байгууллагуудын хоорондох харилцааны мөн чанар нь тэдгээр бусад байгууллагуудыг уг тайлагнагч байгууллага хянадаг гэдгийг илэрхийлдэг эсэх.
139. 137-р параграфын дагуу хийх зарим тодруулгыг бусад УСНББОУС-аар шаардсан байдаг. Жишээлбэл; УСНББОУС 38, *Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцооны Тодруулга* нь бусад байгууллагыг уг байгууллага хянадаг эсэхийг тодорхойлохын тулд хийсэн шүүн тунгаалтаа тодруулахыг тухайн байгууллагаас шаарддаг. УСНББОУС 16, *Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө* нь үл хөдлөх хөрөнгийн ангиллыг тодорхойлоход төвөгтэй байх тохиолдолд хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгөөс болон бизнесийн ердийн үйл ажиллагааны явцад борлуулах зорилгоор эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгөөс тус тус ялган зааглахын тулд тухайн байгууллагын боловсруулсан шалгуурын талаар тодруулга хийхийг шаарддаг.

*Тооцооллын тодорхойгүй байдлын гол эх сурвалж*

140. **Байгууллага нь тодруулгадаа (а) ирээдүйн талаархи гол таамаглалууд, (б) дараагийн санхүүгийн жилийн дотор хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд материаллаг тохируулга хийхэд хүргэх мэдэгдэхүйц эрсдэлтэй, тухайн тайлангийн өдрөөрх тооцооллын тодорхойгүй байдлын бусад гол эх сурвалжийн талаархи мэдээллийг тодруулна. Тодруулга нь тэдгээр хөрөнгө, өр төлбөрийн хувьд доорх дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан байна:**
- (а) **Тэдгээрийн шинж төрөл; ба**
  - (б) **Тайлангийн өдрөөрх тэдгээрийн дансны үнэ.**
141. Зарим хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийг тодорхойлох ажиллагаа нь тэдгээр хөрөнгө, өр төлбөрт ирээдүйн тодорхой бус үйл явдлын үзүүлэх үр нөлөөний талаар тухайн тайлангийн өдрөөр тооцоолол хийхийг шаарддаг. Жишээлбэл; дараах хөрөнгө, өр төлбөрийг хэмжихэд ашигласан, сүүлийн үед ажиглан тогтоосон зах зээлийн үнэ байхгүй тохиолдолд (а) үндсэн хөрөнгийн зарим ангиудын нөхөгдөх дүн, (б) бараа материалд технологийн



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЛИЛУУЛГА

хоцрогдлын үзүүлэх үр нөлөө, (в) шийдвэрлэгдээгүй зарга маргааны ирээдүйн үр дагаварт хамаарах нөөц зэргийг хэмжихийн тулд ирээдүйд чиглэсэн тооцоолол хийх зайлшгүй шаардлагатай байдаг. Эдгээр тооцоолол нь мөнгөн гүйлгээ буюу ашигласан дискаунтын хувь хэмжээнд хийх эрсдлийн тохируулга, бусад өртөг зардалд нөлөөлөх үнийн ирээдүйн өөрчлөлт гэх мэт зүйлсийн талаархи таамаглалыг агуулдаг.

142. 140-р параграфын дагуу тодруулах гол таамаглалууд ба тооцооллын тодорхойгүй байдлын бусад гол эх сурвалж нь удирдлагын хамгийн түвэгтэй, субъектив буюу нарийн цогц шүүн тунгаалт шаардах тооцоололд хамаардаг. Тодорхойгүй байдлын талаархи ирээдүйн боломжит шийдэлд нөлөөлөх хувьсагчууд болон таамаглалуудын тоо нэмэгдэхийн хирээр тэдгээр шүүн тунгаалт нь улам бүр субъектив шинжтэй ба нарийн цогц болох бөгөөд үүний улмаас хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд хийх дагалдах материаллаг тохируулга нь ихэвчлэн нэмэгддэг.
143. Хэрэв сүүлийн үед ажигласан зах зээлийн үнэд үндэслэн тухайн хөрөнгө, өр төлбөрийг уг тайлангийн өдөр бодит үнэ цэнээр хэмжсэн бол тэдгээрийн дансны үнэ нь дараагийн санхүүгийн жилийн дотор материаллаг дүнгээр өөрчлөгдөж болох мэдэгдэхүйц эрсдэлтэй хөрөнгө, өр төлбөрийн хувьд 140-р параграфт заасан тодруулгыг хийх шаардлагагүй юм (тэдгээрийн бодит үнэ цэнэ нь дараагийн санхүүгийн жилийн дотор материаллаг дүнгээр өөрчлөгдөж болох боловч тэрхүү өөрчлөлт нь тухайн тайлангийн өдрөөрх таамаглалууд буюу тооцооллын тодорхойгүй байдлын бусад эх сурвалжаас үүсээгүй байна).
144. Ирээдүйн талаар, түүнчлэн тооцооллын тодорхойгүй байдлын бусад гол эх сурвалжийн талаар удирдлагын хийсэн шүүн тунгаалтуудыг ойлгоход тухайн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд туслах тийм арга маягаар 140-р параграфт заасан тодруулгыг толилуулна. Бүрдүүлэн хангах мэдээллийн шинж төрөл ба хэмжээ нь тухайн таамаглал болон бусад нөхцөл байдлын шинж төрлөөс хамааран янз өөр байдаг. Хийгдэх тодруулгын төрлийн талаархи жишээнүүд дараах байдалтай байна:
- (а) Таамаглал буюу тооцооллын бусад тодорхойгүй байдлын шинж төрөл;
  - (б) Тооцооллыг хийсэн арга, таамаглал болон уг тооцооллын суурь үндэслэл болох тооцооноос хамаарах дансны үнийн мэдрэмж буюу өөрчлөгдөх байдал, түүнчлэн тийм мэдрэмжийн шалтгаан;
  - (в) Тодорхойгүй байдлын хүлээгдэж буй шийдэл ба тухайн нөлөөнд өртсөн хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийн хувьд дараагийн санхүүгийн жилийн дотор гарах ул үндэслэлтэйгээр боломжит үр дагавруудын хамаарах муж; ба
  - (г) Хэрэв уг тодорхойгүй байдал шийдвэрлэгдэхгүй хэвээр байвал тэдгээр хөрөнгө, өр төлбөрийн талаархи өмнөх таамаглалуудад оруулах өөрчлөлтийн талаархи тайлбар.

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЛИЛУУЛГА

145. 140-р параграфт заасан тодруулгыг хийхдээ төсвийн мэдээлэл эсвэл прогнозыг толилуулах шаардлагагүй юм.
146. Гол таамаглалын буюу тооцооллын тодорхойгүй байдлын бусад гол эх сурвалжийн боломжит үр нөлөөний хэмжээг тухайн тайлангийн өдрөөр толилуулах практик боломжгүй тохиолдолд, тэрхүү таамаглалаас өөр байх, дараагийн санхүүгийн жилийн доторх үр дагавар нь тэдгээр нөлөөнд өртсөн хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд материаллаг тохируулга хийхийг шаардах үндэслэлтэйгээр боломжтой гэдгийг уг байгууллага нь өөрийн одоогийн мэдлэгт үндэслэн тодруулна. Аливаа бүх тохиолдолд байгууллага нь уг таамаглалаар нөлөө үзүүлэх тодорхой нэг хөрөнгө буюу өр төлбөр (эсвэл хөрөнгө, өр төлбөрийн анги)-ийн шинж төрөл ба дансны үнийг тодруулна.
147. Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдөх явцад удирдлагын хийсэн тодорхой нэг шүүн тунгаалтын хувьд 137-р параграфт заасан тодруулга нь 140-р параграфт дурдсан тооцооллын тодорхойгүй байдлын гол эх сурвалжийн талаархи тодруулгатай холбоогүй байдаг.
148. 140-р параграфын дагуу тодруулга хийхийг шаардах байснаас бусад, зарим гол таамаглалын талаар тодруулга хийхийг бусад УСНББОУС-аар шаардсан байдаг. Тухайлбал; УСНББОУС 19 нь нөөцийн ангиудад нөлөөлөх ирээдүйн үйл явдлуудын талаархи гол таамаглалуудын хувьд тодорхой нөхцөлд тодруулга хийхийг шаарддаг. Бодит үнэ цэнээр бүртгэсэн санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийг тооцоолохдоо хэрэглэсэн гол таамаглалуудын талаар тодруулга хийхийг УСНББОУС 17-гоор шаарддаг.

### *Капитал*

- 148А. **Байгууллага нь капиталыг удирдан зохицуулах тухай байгууллагын зорилго, бодлого, процессыг үнэлэх боломжийг өөрийн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгох мэдээллийг тодруулна.**
- 148Б. 148А параграфыг даган мөрдөхийн тулд байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:
- (а) Капиталыг удирдан зохицуулах түүний зорилго, бодлого, үйл явцын талаархи чанарын шинжтэй мэдээлэл. Үүнд дараах зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:
- (1) Капитал гэж удирдан зохицуулдаг зүйлийн талаархи тайлбар тодорхойлолт;
  - (2) Байгууллага нь гаднаас хүлээлгэсэн капиталын шаардлагуудад захирагддаг тохиолдолд тэдгээр шаардлагуудын шинж төрөл ба капиталын удирдлагад тэдгээр шаардлагуудыг хэрхэн тусган оруулдаг эсэх; ба
  - (3) Капиталыг удирдан зохицуулах өөрийн зорилтуудыг хэрхэн ханган биелүүлж буй эсэх.

- (б) Капитал гэж удирдан зохицуулдаг зүйлийн талаархи хураангуй тоон мэдээ. Зарим байгууллагууд нь тодорхой нэг санхүүгийн өр төлбөр (жишээлбэл; зарим төрлийн хоёрдогч өглөг)-ийг капиталын нэг хэсэг гэж үздэг. Өөр бусад байгууллагууд нь капиталд өмчийн зарим бүрэлдэхүүн хэсэг (жишээлбэл; мөнгөн гүйлгээний хейжээс үүссэн бүрэлдэхүүн хэсгүүд)-ийг оруулдаггүй.
- (в) Дээрх (а) ба (б)-д өмнөх тайлант үеэс хойш орсон аливаа өөрчлөлтүүд.
- (г) Байгууллага нь өөрийн хамаарах түүнд гаднаас хүлээлгэсэн аливаа капиталын шаардлагуудыг тухайн тайлант үеийн туршид даган биелүүлсэн эсэх.
- (д) Байгууллага нь ийм гаднаас хүлээлгэсэн капиталын шаардлагуудыг даган биелүүлээгүй тохиолдолд ийм үл даган биелүүлэлтийн үр дагавар.

Байгууллага нь эрх бүхий албан тушаалтанд дотооддоо бэлтгэн танилцуулдаг мэдээлэлд үндэслэн эдгээр тодруулгыг хийнэ.

- 148В. Байгууллага нь капиталыг олон арга замаар удирдаж болох бөгөөд капиталын янз бүрийн олон шаардлагуудыг хүлээдэг. Жишээлбэл; том корпораци нь даатгалын болон банкны үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудыг өөртөө багтаасан байх бөгөөд тэдгээр байгууллагууд нь хэд хэдэн улс оронд, янз бүрийн эрх зүйн орчинд үйл ажиллагаа явуулдаг байж болно. Капиталын шаардлагууд ба капиталыг хэрхэн удирддаг талаархи нэгтгэсэн тодруулга нь ач холбогдолтой мэдээллээр хангахгүй буюу байгууллагын капиталын нөөцийн талаархи санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн ойлголтыг төөрөгдүүлэхэд хүргэх тохиолдолд уг байгууллага нь өөрийн хамааран захирагдах капиталын шаардлага тус бүрийн хувьд тусдаа мэдээллийг тодруулна.

*Цэвэр хөрөнгө/өмч гэж ангилсан, Буцаах эрхтэй санхүүгийн хэрэглүүр*

- 148Г. **Өмчийн хэрэглүүр гэж ангилсан, буцаах эрхтэй санхүүгийн хэрэглүүрийн хувьд байгууллага нь (өөр аль нэг хэсэгт тодруулаагүй хэмжээгээр) дараах зүйлсийг тодруулна:**

- (а) **Цэвэр хөрөнгө/өмч гэж ангилсан дүнгийн талаархи хураангуй тоон мэдээ;**
- (б) **Хэрэглүүрийг эзэмшигчдийн шаардлагаар тухайн хэрэглүүрийг буцаан худалдан авах буюу эргэлтээс гаргах өөрийн үүргийг удирдан зохицуулах тухайн байгууллагын зорилго, бодлого, процесс, үүн дотроо өмнөх тайлант үеэс хойш эдгээрт орсон аливаа өөрчлөлтүүд;**
- (в) **Тухайн ангийн санхүүгийн хэрэглүүрийг эргэлтээс гаргах буюу буцаан худалдан авахад зарцуулахаар хүлээгдэж буй мөнгөн зарлага;**

- (г) Эргэлтээс гаргах буюу буцаан худалдан авахад зарцуулахаар хүлээгдэж буй мөнгөн зарлагыг хэрхэн тодорхойлсон талаархи мэдээлэл.

*Бусад тодруулга*

149. **Байгууллага нь тодруулгад дараах зүйлсийг толилуулна:**

- (а) Санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрөхийн өмнө санал болгосон буюу зарласан боловч тухайн тайлант үед эздэд олгох хуваарилалт байдлаар хүлээн зөвшөөрөөгүй байгаа ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтын дүн болон нэгж хувьцаанд ногдох холбогдох дүн; ба
- (б) Давуу эрхийн хувьцааны хүлээн зөвшөөрөөгүй байгаа аливаа хуримтлагдсан ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтын дүн.

150. **Санхүүгийн тайлангийн хамт хэвлэн нийтэлсэн мэдээллийн аль нэг хэсэгт толилуулаагүй бол байгууллага нь дараах зүйлсийг толилуулна:**

- (а) Байгууллагын байнга оршин суух газар ба хуулийн хэлбэр, түүний үйл ажиллагаагаа явуулдаг улс орон;
- (б) Байгууллагын үйл ажиллагааны шинж төрөл ба түүний үндсэн үйл ажиллагаануудын талаархи тайлбар тодорхойлолт;
- (в) Байгууллагын үйл ажиллагааг удирдан зохицуулах холбогдох хууль тогтоомжийн талаархи лавлагаа;
- (г) Хянагч байгууллагын нэр болон эдийн засгийн нэгдмэл байгууллагын эцсийн хянагч байгууллагын нэр (хамааралтай тохиолдолд); ба
- (д) Хэрэв хязгаарлагдмал хугацаанд үйл ажиллагаа явуулах байгууллага бол түүний үйл ажиллагаа явуулах хугацааны талаархи мэдээлэл.

### **Шилжилтийн нөхцөл**

151. [Хассан]

152. [Хассан]

### **Хүчин төгөлдөр болох хугацаа**

153. **Байгууллага нь энэхүү Стандартыг 2008 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2008 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.**

- 153А. 2010 оны 01 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Сайжруулалтууд*-аар 79 ба 82-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2011 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2011 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 153Б. УСНББОУС 28-ын үр дүнд 150-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 7А, 95А, 148Г параграфуудыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2013 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Хэрэв байгууллага нь 2013 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед УСНББОУС 28-ыг мөрдсөн бол эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.
- 153В. УСНББОУС 30-ын үр дүнд 75, 129, 148-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулж, 148А-148В параграфуудыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2013 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Хэрэв байгууллага нь 2013 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед УСНББОУС 30-ыг мөрдсөн бол эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.
- 153Г. 2010 оны 11 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Сайжруулалтууд*-аар 80-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2012 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2012 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 153Д. 2015 оны 01 дүгээр сард гаргасан *УСНББОУС 2014-ийн Сайжруулалтууд*-аар 21, 53, 54-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулж, 53А параграфыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2015 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2015 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 153Е. 2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-ийн үр дүнд 151, 152, 154-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу

түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед УСНББОУС 33-ыг мөрдсөн бол эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.

- 153Ж. 2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан* ба УСНББОУС 38, *Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцооны Тодруулга*-ын үр дүнд 4, 7, 12, 88(п), 95(г), 97, 103, 118(в), 134, 135, 139-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь УСНББОУС 35 ба УСНББОУС 38-ыг мөрдсөн үеэс эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг дагаж мөрдөнө.
- 153И. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд*-аар 29, 44, 70, 73, 74, 109, 116-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулж, Хавсралт А, *Санхүүгийн Тайлагналын Чанарын Шинжүүд*-ийг хассан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 153К. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 5, 6, 12-р параграфуудыг хасаж, 7, 97-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 153Л. 2016 оны 7 дугаар сард гаргасан УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийн үр дүнд 116-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 39-ийг мөрдөнө.
- 153М. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийн үр дүнд 135-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс

**өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.**

154. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

### **УСНББОУС 1 (2000)-ээс татгалзах**

155. Энэ Стандарт нь 2000 онд гаргасан УСНББОУС 1, *Санхүүгийн Тайлангийн Толилуулга*-ыг орлоно.

**Хавсралт А**

**Санхүүгийн Тайлагналын Чанарын Шинжүүд**

*Энэ Хавсралт нь УСНББОУС 1-ийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.*

[Хассан]



## Хавсралт Б

### Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт

[Хассан]

## Дүгнэлтийн Үндэслэл

Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 1-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

**НББОУС3-ийн Ерөнхий Сайжруулалтын Төсөл 2003-ын үр дүнд УСНББОУС 1-ийг хянан засварласан.**

Оршил

- ДҮ1. УСНББОУС3-ийн СТОУС-тай нийцүүлэх хөтөлбөр нь УСНББОУС3-ийн ажлын хөтөлбөрийн чухал элемент юм. УСНББОУС3-ийн бодлого нь улсын секторын байгууллагуудад тохиромжтой тохиолдолд НББОУС3-өөс гаргасан СТОУС-тай аккруэл суурьт УСНББОУС-ыг нийцүүлэх явдал юм.
- ДҮ2. Улсын секторын хувьд гажих тусгай учир шалтгаан байхаас бусад тохиолдолд СТОУС-тай нийцүүлсэн, аккруэл суурьт УСНББОУС нь СТОУС-ын шаардлага, бүтэц, текстийг тэр хэвээр хадгална. СТОУС-ын шаардлага буюу нэр томъёо нь улсын секторт тохиромжгүй эсвэл улсын секторын хувьд зарим тодорхой шаардлагуудыг үлгэрчлэн харуулахын тулд нэмэлт тайлбар буюу жишээ оруулах шаардлагатай тохиолдолд адилтгах СТОУС-аас гаждаг. УСНББОУС-ууд ба тэдгээртэй адилтгах СТОУС-уудын хоорондох ялгаатай талуудыг УСНББОУС нэг бүрд тусган оруулсан *СТОУС-тай Харьцуулалт*-д тодорхойлсон.
- ДҮ3. 2002 оны 5 дугаар сард өөрийн Ерөнхий Сайжруулалтын Төслийн нэг хэсэг болгон НББОУС3 нь 13-н НББОУС<sup>1</sup>-д оруулахаар санал болгосон нэмэлт өөрчлөлтийн саналын төслийг гаргасан. НББОУС3-ийн Ерөнхий Сайжруулалтын Төслийн зорилго нь “Стандартуудын хүрэн дэх сонголтод олон хувилбарууд, илүүдэл зүйлс, зөрчилтэй заалтуудыг арилгах буюу бууруулах, нийцүүлэлтийн зарим асуудлуудыг шийдэх ба бусад сайжруулалтыг хийх”-д оршино. НББОУС-ын эцсийн хувилбарыг 2003 оны 12 дугаар сард гаргасан.
- ДҮ4. 2000 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 1 нь НББОУС 1 (1997 онд хянан засварласан)-д үндэслэсэн. НББОУС 1-ийг 2003 оны 12 дугаар сард дахин гаргасан. УСНББОУС3-ийн өмнөх байгууллага болох Улсын Секторын Хороо (УСХ)<sup>2</sup> нь 2003 оны 12 дугаар сард гаргасан, сайжруулсан НББОУС-тай тохиромжтой хэмжээгээр УСНББОУС-ыг нийцүүлэхийн тулд УСНББОУС-ыг сайжруулах төслийг 2003 оны эцсээр хэрэгжүүлж эхэлсэн.

---

<sup>1</sup> НББОУС3-ийн өмнөх байгууллага болох НББОУСХ-ноос НББОУС-ыг гаргасан. НББОУС3-өөс гаргасан стандартуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) гэж нэрлэдэг. СТОУС-ыг НББОУС3 нь СТОУС, НББОУС, Стандартын Тайлбаруудаас бүрдэнэ гэж тодорхойлсон. Зарим тохиолдолд НББОУС3 нь НББОУС-ыг сольж орлуулахгүй, харин нэмэлт өөрчлөлт оруулдаг бөгөөд ингэснээр хуучин НББОУС-ын дугаарлалт хэвээр үлддэг.

<sup>2</sup> ДНБХ-ны Зөвлөл нь УСХ-г стандарт тогтоох бие даасан зөвлөл болгохын тулд түүний бүрэн эрхийг 2004 оны 11 дүгээр сард өөрчилснөөр УСХ нь УСНББОУС3 болсон.

- ДҮ5. УСНББОУСЗ нь уг сайжруулсан НББОУС 1-ийг нягталж шалгаад ингэж хянан засварлах болсон НББОУСЗ-ийн учир шалтгаан болон хийсэн нэмэлт өөрчлөлттэй ерөнхийдөө санал нэгдсэн. (НББОУСЗ-ийн Дүгнэлтийн Үндэслэлийг энд дахин нийтлээгүй болно. НББОУСЗ-ийн *Цогц Захиалгын Үйлчилгээ*-гээр захиалагч нар нь [www.iasb.org](http://www.iasb.org) хаягаар орж, НББОУСЗ-ийн вэб сайтаас Дүгнэлтийн Үндэслэлийг үзэж болно). УСНББОУС нь адилтгах НББОУС-аас гажих тохиолдолд улсын секторын хувьд гажих тусгай учир шалтгааныг Дүгнэлтийн Үндэслэлд тайлбарладаг.
- ДҮ6. 2003 оны 12 дугаар сараас хойш гаргасан СТОУС-уудын үр дүнд НББОУС 1-д цаашид нэмэлт өөрчлөлт оруулсан. 2003 оны 12 дугаар сараас хойш гаргасан СТОУС-уудын үр дүн болох нэмэлт өөрчлөлтүүдийг УСНББОУС 1-д тусган оруулаагүй байна. Яагаад гэвэл, УСНББОУСЗ нь тэдгээр СТОУС-уудын шаардлагуудыг нягтлан шалгаж, улсын секторын байгууллагуудад мөрдөгдөх боломжит байдлын талаар өөрийн үзэл бодлыг хараахан илэрхийлээгүй байгаа юм.

#### Орлого

- ДҮ7. НББОУС 1 нь орлого /income/ нэр томъёог ашигладаг, харин УСНББОУС 1-д үүнийг ашигладаггүй. УСНББОУС 1-д орлого /revenue/ гэсэн нэр томъёог ашигладаг бөгөөд энэ нь НББОУС/СТОУС-д ашигласан орлого /income/ нэр томъёотой нийцэх юм. Орлого /income/ нэр томъёо нь орлогоос /revenue/ илүү өргөн хүрээтэй ба олзыг мөн өөртөө агуулсан байдаг. УСНББОУС нь орлогын /income/ тодорхойлолтыг тусгаагүй, ийм тодорхойлолтын нэвтрүүлэлт нь сайжруулах төслийн нэг хэсэг биш бөгөөд Саналын Төсөл 26-д тусгагдаагүй.

#### Онцгой шинжтэй зүйлс

- ДҮ8. Байгууллага нь орлого, зардлын аливаа нэг зүйлийг орлогын тайланд эсвэл тодруулгад онцгой шинжтэй зүйлс гэж толилуулахыг НББОУС 1-ээр хориглодог. НББОУСЗ нь онцгой гэж үзсэн зүйлс тухайн байгууллагад тулгарсан хэвийн бизнесийн эрсдлээс үүсдэг бөгөөд орлогын тайлангийн тусдаа бүрэлдэхүүн хэсэг байдлаар толилуулах үндэслэл болохгүй гэж дүгнэсэн. Ажил гүйлгээ буюу бусад үйл явдлын давтамж биш, харин шинж төрөл буюу чиг үүрэг нь орлогын тайлан дахь түүний толилуулгыг тодорхойлдог байвал зохино.
- ДҮ9. УСНББОУС 1 (2000 он)-д заасан, онцгой шинжтэй зүйлсийн тодорхойлолт нь НББОУС 8, *Тайлант Үеийн Цэвэр Ашиг буюу Алдагдал, Суурь Алдаа ба Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Өөрчлөлт*<sup>3</sup>-ийн өмнөх хувилбарт

---

<sup>3</sup> УСНББОУС 1 (2000) нь онцгой шинжтэй зүйлсийг “байгууллагын ердийн үйл ажиллагаанаас эрс ялгаатай үйл явдал буюу ажил гүйлгээнээс үүсдэг, байнга буюу дахин давтагдан гарахаар хүлээгдээгүй бөгөөд тухайн байгууллагын хяналт буюу нөлөөллөөс ангид байх орлого, зардал” гэж тодорхойлсон. НББОУС 8 нь “онцгой шинжтэй зүйлс”-ийг “аж ахуйн нэгжийн ердийн үйл ажиллагаанаас эрс ялгаатай үйл явдал буюу ажил гүйлгээнээс үүсдэг, иймээс байнга буюу дахин давтагдан гарахаар хүлээгдээгүй орлого, зардал” гэж тодорхойлсон.

(1993 он) тусгасан, онцгой шинжтэй зүйлсийн тодорхойлолтоос өөр байдаг. Энэхүү ялгаатай байдал нь улсын секторын байгууллагуудын хувьд онцгой шинжтэй зүйл юунаас бүрдэх талаархи улсын секторын үзэл баримтлалыг тусгасан байдаг.

ДҮ10. Энэхүү Стандарт нь орлого, зардлын зүйлсийг санхүүгийн үр дүнгийн тайланд эсвэл тодруулгад онцгой шинжтэй зүйлс гэж толилуулахыг илт хориглодоггүй. НББОУС 1 нь орлого, зардлын аливаа зүйлсийг орлогын тайланд эсвэл тодруулгад онцгой шинжтэй зүйлс гэж толилуулахыг хориглодог. УСНББОУС3 нь онцгой шинжтэй зүйлсийг байгууллага өөрийн тодруулгад эсвэл санхүүгийн үр дүнгийн тайланд толилуулахыг УСНББОУС-аар хориглох хэрэггүй гэсэн байр суурьтай байдаг. Яагаад гэвэл, тэд онцгой шинжтэй зүйлсийн талаархи мэдээллийн тодруулга нь санхүүгийн тайлагналын зорилго ба чанарын шинжүүдтэй нийцэж болох юм гэж үздэг. Гэвч зарим гишүүд нь энэхүү асуудлын талаархи НББОУС 1-ийн шаардлагуудаас гажих улсын секторын тусгай учир шалтгаан байхгүй гэж үздэг. Засгийн газрын ердийн үйл ажиллагаанаас ялгаатай зүйлс нь материаллаг байх тохиолдолд санхүүгийн тайланд эсвэл тодруулгад тэдгээрийг тусдаа толилуулахыг УСНББОУС 1-ээр хориглоогүй гэдгийг тэд мөн тэмдэглэсэн. Санхүүгийн тайланд “онцгой шинжтэй зүйлс”-ийг толилуулах НББОУС3-ийн хориглолтоос гажих, улсын секторын тусгай учир шалтгаан байгаа эсэхэд тэд бүрэн итгэлгүй байдаг.

**2008 онд гаргасан, НББОУС3-ийн *СТОУС-ын Сайжруулалтууд*-ын үр дүнд УСНББОУС 1-д хийсэн хянан засварлалт**

ДҮ11. УСНББОУС3 нь 2008 оны 5 дугаар сард НББОУС3-өөс гаргасан *СТОУС-ын Сайжруулалтууд*-д тусгасан, НББОУС 1-ийн хянан засварлалтыг нягталж шалгаад уг Стандартыг хянан засварлах болсон НББОУС3-ийн учир шалтгаантай ерөнхийдөө санал нийлсэн. УСНББОУС3 нь уг нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдөхгүй байх улсын секторын тусгай учир шалтгаан байхгүй гэж дүгнэсэн.

**2009 онд гаргасан, НББОУС3-ийн *СТОУС-ын Сайжруулалтууд*-ын үр дүнд УСНББОУС 1-д хийсэн хянан засварлалт**

ДҮ12. УСНББОУС3 нь 2009 оны 4 дүгээр сард НББОУС3-өөс гаргасан *СТОУС-ын Сайжруулалтууд*-д тусгасан, НББОУС 1-ийн хянан засварлалтыг нягталж шалгаад уг Стандартыг хянан засварлах болсон НББОУС3-ийн учир шалтгаантай ерөнхийдөө санал нийлсэн. УСНББОУС3 нь уг нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдөхгүй байх улсын секторын тусгай учир шалтгаан байхгүй гэж дүгнэсэн.

**2012 оны 5 дугаар сард гаргасан, НББОУС3-ийн *СТОУС-ын Сайжруулалтууд*-ын үр дүнд УСНББОУС 1-д хийсэн хянан засварлалт**

ДҮ13. УСНББОУС3 нь 2012 оны 5 дугаар сард НББОУС3-өөс гаргасан *СТОУС-ын Сайжруулалтууд*-д тусгасан, НББОУС 1-ийн хянан засварлалтыг нягталж шалгаад зарим нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдөхгүй байх улсын

секторын тусгай учир шалтгаан байхгүй гэдэгтэй ерөнхийдөө санал нийлсэн. Зарим нэмэлт өөрчлөлтүүд нь СТОУС 1 *Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартыг Анх Удаа Мөрдөх* болон НББОУС 34 *Завсрын Үеийн Санхүүгийн Тайлагнал*-д нөлөө үзүүлсэн, эдгээртэй адилтгах стандартууд УСНББОУС-д байхгүй, иймээс уг нэмэлт өөрчлөлтүүдийг оруулаагүй гэдгийг УСНББОУС3 тэмдэглэсэн. Түүнчлэн, нэмэлт өөрчлөлтийн зарим хэсэг нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, дахин тайлагнал, дахин ангиллаас үүссэн буцаах горимын өөрчлөлтийн хувьд өмнөх тайлант үеийн эхэн дэх санхүүгийн байдлын тайланг толилуулахтай холбоотой байсан. Эхлэлийн санхүүгийн байдлын тайлангийн толилуулга нь одоогоор УСНББОУС 1-ийн шаардлага биш бөгөөд НББОУС3-ийн эдгээр нэмэлт өөрчлөлтүүдтэй холбоотой өөрчлөлтийн нэвтрүүлэлтийг жижиг засвар өөрчлөлт гэж үзэхгүй, иймээс эдгээрийг оруулаагүй. Зэрэгцүүлэгдэх нэмэлт мэдээллийг толилуулахтай холбоотой нэмэлт өөрчлөлтийн хэсгийг жижиг засвар өөрчлөлт гэж үзэхгүй, иймээс тэдгээрийг бас оруулаагүй болно.

**УСНББОУС3-ийн Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал-ын эхний дөрвөн бүлгийн үр дүнд УСНББОУС 1-д хийсэн хянан засварлалт**

ДҮ14. *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал* (Онолын Үзэл Баримтлал)-ыг иж бүрэн болгосны дараа, УСНББОУС3 нь уг Онолын Үзэл Баримтлалын эхний дөрвөн бүлгийг тусгахын тулд УСНББОУС-уудад өөрчлөлт оруулах хязгаарлагдмал цар хүрээ бүхий төслийг эхлүүлсэн. Эдгээр бүлэгт үүрэг ба бүрэн эрх, зорилго ба хэрэглэгчид, чанарын шинжүүд (ЧШ), нийтлэг зорилготой санхүүгийн тайлан дахь мэдээллийн хязгаарлагдмал талууд, тайлагнагч байгууллагыг авч үзсэн. Онолын Үзэл Баримтлал нь “найджартай байдал”-ын оронд, “үнэн зөв толилуулга” гэсэн чанарын шинжийг хэрэглэдэг.

ДҮ15. УСНББОУС 1-ийн 2000 оны 5 дугаар сард гаргасан хувилбар ба 2006 оны 12 дугаар сард гаргасан хувилбарын аль аль нь УСНББОУС3-өөс шууд бусаар батлан мөрдүүлсэн ЧШ ба хязгаарлагдмал талуудыг нэгтгэн товчоолсон, хавсралтыг агуулсан байдаг. Эдгээр ЧШ ба хязгаарлагдмал талуудыг өмнөх Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Хорооны 1989 оны Онолын Үзэл Баримтлалд үндэслэн бэлтгэсэн. УСНББОУС3 нь өөрийн Онолын Үзэл Баримтлалд ЧШ болон хязгаарлагдмал талуудыг тусгахын тулд энэхүү Хавсралтанд нэмэлт өөрчлөлт оруулах эсвэл түүнийг бүхэлд нь хүчингүй болгох эсэхийг харгалзан үзсэн. Онолын Үзэл Баримтлал дахь ойлголт ухагдахууныг хоёрдогч эх сурвалжаар дамжуулахын оронд шууд харгалзан тусгах нь чухал ач холбогдолтой гэж УСНББОУС3 шийдвэрлэсэн. Иймээс УСНББОУС3 нь Хавсралт А-г бүхэлд нь хүчингүй болгохоор шийдвэрлэсэн. Энэхүү шийдвэртэй нийцүүлэн УСНББОУС3 нь УСНББОУС 18, *Сегментийн Тайлагнал* дахь Хавсралт А-гийн хуулбарыг мөн хүчингүй болгохоор шийдвэрлэсэн.

ДҮ16. УСНББОУС дахь хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт “найдвартай” буюу “найдвартай байдал” гэсэн үг хэллэг орсон гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн байдаг. Бусад олон УСНББОУС нь хүлээн зөвшөөрөлтийн нарийвчилсан шалгуурыг тусгаагүй боловч хүлээн зөвшөөрөлт, тооцоолол, хуваарилалт болон хэмжилттэй холбоотой бусад асуудлуудын талаархи илүү ерөнхий заавар удирдамжид “найдвартай” буюу “найдвартай байдал” гэсэн хэллэгийг дурдсан байдаг. УСНББОУСЗ нь хүлээн зөвшөөрөлтийн шалгуур болон холбогдох заавар удирдамжийг бүрэн нягталж шалгахгүйгээр хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт хэсэгчилсэн өөрчлөлт хийх нь зохистой гэж үздэггүй. Иймээс УСНББОУСЗ нь УСНББОУС нэг бүрд “найдвартай байдал” гэдгийн утгыг тайлбарласан хөлийн тэмдэглэлийг хүлээн зөвшөөрөлтийн шалгуур буюу хэмжилтийн төлөв байдлын талаархи холбогдох заавар удирдамжийн хамт оруулахаар шийдвэрлэсэн. Ийм хөлийн тэмдэглэлд “найдвартай мэдээлэл нь материаллаг алдаа ба туйлшралаас ангид байх бөгөөд өөрийн илэрхийлэхээр зориулагдсан буюу илэрхийлнэ гэж ул үндэслэлтэйгээр хүлээж болох зүйлсийг үнэн зөв илэрхийлэхдээ хэрэглэгчдээс хамаарч болох мэдээлэл” гэж дурдсан байдаг.

**2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУСЗ-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 1-д хийсэн хянан засварлалт**

*Оршил*

ДҮ17. УСНББОУС 1 нь Улсын Үйлдвэрийн Газар (УҮГ)-ын дараах тодорхойлолтыг тусгасан байдаг:

*Улсын үйлдвэрийн газар гэдэг нь дараах бүх шинж чанар бүхий байгууллагыг хэлнэ:*

- (а) Байгууллага нь өөрийн нэрийн өмнөөс гэрээ байгуулах бүрэн эрхтэй байх;*
- (б) Бизнесийг эрхлэн явуулах санхүүгийн болон үйл ажиллагааны эрх олгогдсон байх;*
- (в) Өөрийн бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад бараа, үйлчилгээг бусдад ашигтайгаар эсвэл бүрэн өртгийг нөхөх дүнгээр борлуулдаг байх;*
- (г) Тасралтгүй байдлаар үйл ажиллагаагаа явуулахын тулд (холбоогүй талуудын ажил гүйлгээгээр бүтээгдэхүүнийг худалдан авахаас бусад тохиолдолд) Засгийн газрын байнгын санхүүжилтээс хамааралтай бус байх; ба*
- (д) Улсын секторын байгууллагын хяналтанд байх.*

ДҮ18. Энэ тодорхойлолтын зорилго нь УҮГ-ын дээрх тодорхойлолтыг хангаж буй улсын секторын худалдаа арилжааны байгууллагуудыг УСНББОУС-ын цар хүрээнээс хасах явдал юм. Гэвч УСНББОУСЗ-ийн хүлээн авсан эргэх холбоо буюу санал хүсэлт нь УҮГ гэж тодорхойлж болох маш олон төрлийн

байгууллагууд байдаг бөгөөд тэдгээрийн зарим нь УҮГ-ын талаархи УСНББОУСЗ-ийн тодорхойлолтыг мэдээж хангахгүй гэдгийг харуулсан.

ДҮ19. Энэхүү асуудлыг авч үзэхийн тулд 2014 оны 8 дугаар сард УСНББОУСЗ нь Зөвлөлдөх Баримт Бичиг (ЗББ), *Улсын Үйлдвэрийн Газрууд болон Улсын Секторын Бусад Байгууллагуудад УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Нягтлан бодох бүртгэлийн стандартаа боловсруулж буй улсын секторын байгууллагууд болон УҮГ-уудад өөрийн бодлогыг хүргэн танилцуулахын тулд ЗББ-ээр хоёр гол хандлагыг санал болгосон.

ДҮ20. Хандлага 1 нь дараах зүйлсийг санал болгосон: (i) УҮГ-ын тодорхойлолтыг хасах, (ii) УСНББОУС-ын хамааран үйлчлэх улсын секторын байгууллагуудын шинж чанарын талаархи өндөр түвшний тайлбар тодорхойлолтоор хангах. Энэхүү хандлага нь хоёр сонголттой. Үүнд: УСНББОУСЗ-ийн одоогийн болон цаашид боловсруулж буй бүтээлийг ашиглах (Сонголт 1а) эсвэл Засгийн Газрын Санхүүгийн Статистик (ЗГСС)-ийн тайлагналын заавар ба тайлбар заавар удирдамжийг ашиглах (Сонголт 1б).

ДҮ21. Сонголт 1а-гийн дагуу УСНББОУСЗ нь улсын секторын байгууллагуудын шинж чанарыг дараах байдлаар тодорхойлох юм:

УСНББОУС-ыг доорх байгууллагуудад мөрдөхөөр төлөвлөн зохиомжилсон байдаг:

- (а) Юуны өмнө өөрсдийн үйлчилгээний чадавхид зориулан эзэмшдэг хөрөнгүүдээр олон нийтэд үйлчилгээ үзүүлэх<sup>4</sup> ба орлого, баялагийг дахин хуваарилахын тулд шилжүүлгийн төлбөр<sup>5</sup> хийх хариуцлага хүлээдэг;
- (б) Үйл ажиллагаагаа татвар, засгийн газрын бусад түвшний байгууллагаас авах шилжүүлэг, нийгмийн хувь оролцоо, төлбөр буюу хураамжаар шууд болон шууд бусаар санхүүжүүлдэг бөгөөд өөрсдийн хөрөнгө оруулалтаас өгөөж олох эсвэл хөрөнгө оруулалтыг буцаан авахыг эрмэлзэх капиталын нийлүүлэгчидгүй байна;

ДҮ22. Хандлага 2 нь УСНББОУС 1-ийн мөрдөлтөнд тулгарах асуудлуудыг шийдвэрлэхийн тулд УҮГ-ын тодорхойлолтыг хэвээр үлдээж, засварлан өөрчлөх ба уг тодорхойлолтын засвар өөрчлөлтийн хувьд хоёр сонголтыг санал болгосон. Сонголт 2а нь УҮГ-ын одоогийн тодорхойлолтыг илүү ойлгомжтой болгохыг санал болгосон, харин сонголт 2б нь УҮГ-ын одоогийн тодорхойлолтыг илүү хураангуй болгохыг санал болгосон.

---

<sup>4</sup> Үйлчилгээ нь бараа ба үйлчилгээг агуулна.

<sup>5</sup> Transfer/Transfer payment-Шилжүүлэг/Шилжүүлгийн төлбөр гэдэг нь аль нэг талаас хариу төлбөр авахгүйгээр хийдэг төлбөр юм. Жишээлбэл; хандивлагч ба хандив хүлээн авагчийн хооронд хийгдэх төлбөр, Засгийн газраас буцалтгүй тусламж, татаас байдлаар олгох төлбөр, байгууллагаас Засгийн газарт хууль тогтоомжийн дагуу төлөх төлбөр гэх мэт. Харин нөгөө талаас, арилжааны ажил гүйлгээний (exchange transaction) хувьд оролцогч бүх талууд нь зохих өгөөж хүртэх буюу хариу төлбөр авахаар байдаг. Ред.Ч.Д.

- ДҮ23. УСНББОУС-ын төлөвлөн зориулагдсан улсын секторын байгууллагуудын шинж чанарт Хандлага 1 нь төвлөрөн чиглэдэг учраас УСНББОУСЗ нь Хандлага 1 хамгийн тохиромжтой гэсэн Анхдагч Үзэл Бодлыг ЗББ-т санал нэгтгэйгээр илэрхийлсэн. Сонголт 1а нь *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал* (Онолын Үзэл Баримтлал)-д тулгуурлах ба УСНББОУС-ыг мөрдвөл зохих байгууллагуудыг тодорхойлоход зохицуулагчид болон бусад холбогдох эрх бүхий байгууллагуудын гүйцэтгэх үүргийг хүлээн зөвшөөрдөг, өндөр түвшний, зарчимд суурилсан хандлага учраас УСНББОУСЗ-ийн олонх гишүүд нь үүнийг дэмжсэн.
- ДҮ24. Сонголт 1а-д санал өгөгчид нь хүчтэй дэмжлэг үзүүлсэн. Санал өгөгчид нь өмнөх параграфт дурдсан учир шалтгааны улмаас Сонголт 1а-г ерөнхийдөө дэмжсэн. Зарим санал өгөгчид нь Сонголт 1а-г дэмжих нэмэлт учир шалтгааныг мөн илэрхийлсэн. Эдгээр учир шалтгаан нь УСНББОУСЗ хяналт тавьж чадахгүй байх ба УСНББОУСЗ-ийн хэвлэл бүтээлтэй үл нийцэх боломжит байдлыг Сонголт 1б-тэй холбоотой эрсдэл гэж тогтоосон гуравдагч талын хэвлэл бүтээлд тулгуурлаж байсан.
- ДҮ25. Санал өгөгчид нь Сонголт 1а-г дэмжихгүй байх учир шалтгаанд дараах зүйлс хамаарна:
- (а) Буурай хөгжилтэй улс орнуудын хувьд зохицуулагчдын нөөц чадавхи хангалтгүй, иймээс тайлагналын шаардлагуудын нарийвчилсан шалгуурыг боловсруулахад хүндрэлтэй болно;
  - (б) Янз бүрийн улс үндэстнүүдийн зохицуулагчид нь өөр өөр шалгуур ашигласнаар улс орнуудын хоорондох тууштай байдлыг бууруулна;
  - (в) Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдтэй харьцуулахад улсын секторын байгууллагуудын нарийн цогц байдал нь тайлагналын шаардлагуудыг тодорхойлоход өөр хандлага ашиглахыг шаардана.
- ДҮ26. Өөрийн шийдвэрийг гаргахын тулд УСНББОУСЗ нь дараах зүйлсийг харгалзан үзсэн:
- (а) Тухайн улс орны улсын секторын байгууллагуудын хувьд нягтлан бодох бүртгэлийн үзэл баримтлалыг тодорхойлоход зохицуулагчдын гүйцэтгэх үүрэг нь өөр өөр байж болох;
  - (б) УСНББОУС ба УҮГ-ын тайлагналын зааврын хоорондох нийцтэй байдал;
  - (в) Онолын Үзэл Баримтлалын Оршлыг лавлагаа болгон харгалзсан “улсын сектор” нэр томъёоны утга агуулга;
  - (г) Мөнгө бий болгох биш, харин үйлчилгээний чадавхид зориулан эзэмшиж буй хөрөнгүүд нь УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын ялган тодорхойлох шинж чанар хэрхэн болох эсэх; ба



- (д) Улсын үйлдвэрийн газар нэр томъёог “худалдаа арилжааны байгууллага” ба “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёоны аль тохиромжтойгоор сольж орлуулах.

*Зохицуулагчид болон бусад холбогдох эрх бүхий байгууллагуудын үүрэг*

ДҮ27. Зохицуулагчид болон бусад холбогдох эрх бүхий байгууллагууд нь улс орон бүрд УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаар УСНББОУСЗ-өөс өөр үзэл бодолтой байж болно гэдгийг УСНББОУСЗ мэдэгдсэн. Олон улс орнууд нь УСНББОУС-ыг мөрдвөл зохих байгууллагуудыг тодорхойлох өөрсдийн шалгуурыг боловсруулсан байдаг. Эдгээр шалгуур нь хуулийн, эдийн засгийн буюу төсвийн учир шалтгааны улмаас өөр өөр байж болно. Иймээс УСНББОУСЗ нь зарчимд суурилсан хандлага тохиромжтой гэсэн байр суурьтай байдаг. Яагаад гэвэл, ийм хандлага нь улс орон бүрд уян хатан байх боломж олгодог.

*УСНББОУС ба УУГ-ын тайлагналын зааврын хоорондох нийцтэй байдал*

ДҮ28. УСНББОУСЗ нь УСНББОУС ба УУГ-ын тайлагналын зааврын хоорондох зайлшгүй бус зөрүүтэй талуудыг тохиромжтой хэмжээгээр бууруулах бодлого баримталдаг. УСНББОУСЗ нь гуравдагч талын зааварт найдахын оронд өөрийн хянадаг, УСНББОУСЗ-ийн одоогийн болон цаашид хөгжүүлэн боловсруулах хэвлэл бүтээлд үндэслэн шинж чанаруудыг боловсруулснаар санхүүгийн тайлагналын зорилтуудад илүү сайн үйлчилж, УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи асуудлуудыг шийдвэрлэсэн.

*“Улсын сектор” нэр томъёоны утга агуулга*

ДҮ29. Үзэл Баримтлалын 1.8-р параграфт заасанчлан, “улсын сектор” нэр томъёонд үндэсний, бүсийн, мужийн/хөдөөгийн, орон нутгийн засгийн газрууд хамаардаг. Үүнд мөн олон улсын төр засгийн байгууллагууд хамаарна. Хөрөнгө оруулагчдад өмчийн өгөөж олгохыг эрмэлздэг бусад байгууллагууд нь улсын секторт бас хамаарна гэдгийг УСНББОУСЗ мэдэгдсэн. Энэ төрлийн байгууллагуудын нийтлэг зорилготой санхүүгийн тайланд УСНББОУС-ыг мөрдөх зориулалтгүй байдаг. Гэвч УСНББОУС-ыг мөрддөг, хяналт тавигч байгууллага нь нэгтгэсэн санхүүгийн тайландаа ийм байгууллагыг тусган оруулдаг тохиолдолд уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцүүлэхийн тулд зохих тохируулгыг хийнэ. Иймээс УСНББОУСЗ-ийн үзэл бодлоор бол, улсын сектор нэр томъёо нь Онолын Үзэл Баримтлалд дурдсанчлан, нэг байгууллагад болон групп байгууллагад хамааралтай байх юм.

*Үйлчилгээний чадавхид зориулан эзэмшиж буй хөрөнгүүд*

ДҮ30. УСНББОУСЗ-ийн үзэл бодлоор бол, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршилд* заасан, “олон нийтэд үйлчилгээ үзүүлэх хариуцлагатай” гэсэн тайлбар тодорхойлолт нь мөнгө бий болгох биш, харин юуны өмнө үйлчилгээний чадавхийн зорилгоор хөрөнгийг эзэмшдэг улсын секторын байгууллагуудад УСНББОУС зориулагдсан гэдгийг илэрхийлдэг.

*Худалдаа арилжааны байгууллага ба улсын секторын худалдаа арилжааны байгууллага*

ДҮ31. УСНББОУСЗ-ийн үзэл бодлоор бол, улсын сектор нь зөвхөн УСНББОУС-ыг мөрдөх байгууллагууд төдийгүй худалдаа арилжааны байгууллагуудаас бүрдэх учраас “УҮГ” нэр томъёог шууд хасах нь УСНББОУСЗ-ийн хэвлэл бүтээлд хоосон орон зай үлдээх юм. Иймээс УСНББОУСЗ нь “УҮГ” нэр томъёог “худалдаа арилжааны байгууллага” ба “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёоны аль тохиромжтойгоор сольж орлуулахыг санал болгосон.

*Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын засвар өөрчлөлт*

ДҮ32. 2015 оны 8 дугаар сард УСНББОУСЗ нь Саналын Төсөл (СТ) 56, *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Уг СТ нь УСНББОУС 1 болон бусад УСНББОУС, СБПУ-аас УҮГ-ын тодорхойлолтыг хасах УСНББОУСЗ-ийн шийдвэрийг тусгасан байдаг. Энэ хандлага нь хоёрдмол утгатай ба хэрэгжүүлэхэд төвөгтэй тодорхойлолтыг хасаж, УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын шинж чанарыг тодорхойлдог учраас олон нийтийн эрх ашигт хамгийн сайн үйлчилнэ гэж УСНББОУСЗ үзсэн. УСНББОУСЗ нь *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршилд* энэ тайлбар тодорхойлолтыг оруулах ба уг санал болгосон тайлбар тодорхойлолтыг УСНББОУСЗ-ийн хэвлэл бүтээлд үндэслэл болгох санал гаргасан. Хэдийгээр УСНББОУСЗ-ийн албан үйл ажиллагаанд хамаарахгүй боловч УСНББОУСЗ нь уг хянан засварласан шинж чанаруудыг СТ 56-гийн Хураангуйд тусган оруулсан.

*СТ-д өгсөн хариулт*

ДҮ33. Нийт санал өгөгчид нь уг санал болгосон хандлага ба дараах зүйлстэй холбоотой ихэнх санал зөвлөмжийг дэмжсэн:

- (а) УСНББОУС-ын Оршлын 10-р параграф дахь улсын секторын байгууллагуудын шинж чанарууд;
- (б) “Худалдаа арилжааны байгууллага” ба “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” гэсэн үг хэллэг ашиглалт;
- (в) УСНББОУСЗ-ийн хэвлэл бүтээлд оруулах бусад нэмэлт өөрчлөлт.

*УСНББОУС-ын Оршлын 10-р параграф дахь улсын секторын байгууллагуудын шинж чанарууд*

ДҮ34. Улсын секторын байгууллагуудын шинж чанаруудын тайлбар тодорхойлолтын хувьд зарчимд суурилсан хандлагыг хэвээр хадгалахын зэрэгцээгээр, Онолын Үзэл Баримтлалтай нийцсэн байдлыг нэмэгдүүлэхийн тулд тэдгээр санал өгөгчдийн санал зөвлөмжийг УСНББОУСЗ зөвшөөрсөн гэдгийг тусгах үүднээс УСНББОУС-ын Оршлын 10-р параграфт дурдсан, улсын секторын байгууллагуудын шинж чанаруудад нэмэлт өөрчлөлт оруулсан.

ДҮ35. Зарим санал өгөгчид нь Онолын Үзэл Баримтлалын нэр томъёотой нийцүүлэхийн тулд 10(б) параграфт дурдсан, “капитал нийлүүлэгч” гэсэн хэллэгийг “өмч нийлүүлэгч” болгон өөрчлөх хэрэгтэй эсэх санал гаргасан. Өөр зарим санал өгөгчид нь тухайн байгууллага ашгийн төлөө бус зорилготой нь тодорхой учраас “капитал нийлүүлэгч” гэсэн хэллэг шаардлага гэж үзсэн. УСНББОУСЗ нь энэхүү саналыг зөвшөөрч, “капитал нийлүүлэгч” гэсэн хэллэгийг хасахаар шийдвэрлэсэн.

*Улсын секторын худалдаа арилжааны байгууллага*

ДҮ36. СТ-д УСНББОУСЗ нь “УҮГ” нэр томъёог “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” ба “худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулахыг санал болгосон. Тухайн хэлэлцүүлэг нь улсын секторын талаар гэдэг нь тодорхой ойлгомжтой гэж УСНББОУСЗ үзсэн тохиолдолд хураангуй илэрхийлэх үүднээс “худалдаа арилжааны байгууллага” нэр томъёог ашигладаг. Гэвч зарим санал өгөгчдийн үзэл бодлоор бол, нэг төрлийн байгууллагын хувьд өөр өөр нэр томъёо ашиглах нь будлиан үүсгэж болох юм. Иймээс УСНББОУСЗ нь “УҮГ” нэр томъёог “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” гэсэн нэг нэр томъёогоор орлуулахаар шийдвэрлэсэн бөгөөд зохицуулагч нар нь тухайн улс орны хүчин зүйлсийг харгалзан үзсэнээр уг нэр томъёог тайлбарлаж болно гэж мэдэгдсэн.

*УСНББОУСЗ-ийн хэвлэл бүтээлд оруулсан бусад нэмэлт өөрчлөлт*

ДҮ37. Зарим санал өгөгчид нь УСНББОУСЗ-ийн хэвлэл бүтээлээс “УҮГ-аас бусад” гэсэн үг хэллэгийг хассанаар тэдгээр стандартыг мөрдөх улсын секторын байгууллагуудад УСНББОУС-ыг төвлөрүүлэн чиглүүлэхийг санал гаргасан. СТ нь “худалдаа арилжааны байгууллагаас бусад” гэсэн үг хэллэгийг санал болгосон. Тэдгээр санал өгөгчдийн санал нь УСНББОУС-ыг төлөвлөн зориулаагүй байгууллагуудад, үүн дотроо улсын секторын худалдаа арилжааны байгууллагуудад голлон анхаарахын оронд УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудыг эерэг утгаар хүргэн илэрхийлэх ба СТ-ийн хандлагатай нийцэх учраас УСНББОУСЗ нь уг санал өгөгчдийн саналыг хүлээн зөвшөөрч, тухайн үг хэллэгийг хассан.

ДҮ38. Бусад санал өгөгчид нь өмнө авч хэлэлцсэн УСНББОУСЗ-ийн хэвлэл бүтээлд өөрчлөлт оруулахыг санал болгосон. Үүнд:

- Эргэлзээтэй тохиолдлын талаар тайлбар бэлтгэх – Зарим санал өгөгчид нь “цэвэр” улсын секторын байгууллагууд ба “цэвэр” ашгийн төлөө байгууллагуудын хоорондох ялгааны талаар илүү дэлгэрэнгүй тайлбарыг санал болгосон. Тухайлбал; улсын секторын байгууллага нь ашгийн төлөө бус боловч ашигтай байж болох юм. УСНББОУСЗ-ийн үзэл бодлоор бол, аль байгууллага УСНББОУС-ыг мөрдөхийг зохицуулагч нар шийдвэрлэж болох юм.
- Зорилгын өөрчлөлт нь УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын өөрчлөлт гэсэн утгыг илэрхийлж болно. УСНББОУСЗ-ийн үзэл бодлоор бол, улсын секторын байгууллагууд нь өөрсдийн нягтлан бодох

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЛИЛУУЛГА

бүртгэлийн үзэл баримтлалыг өөрчлөх тохиолдолд зохицуулагч нар нь уг шилжилтийн шаардлагуудыг боловсруулах үүрэгтэй байна.

## **Хэрэгжүүлэх заавар удирдамж**

*Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 1-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### **Үлгэрчилсэн санхүүгийн тайлангийн бүтэц**

ХЗУ5. Энэхүү Стандарт нь санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгүүд, санхүүгийн байдлын тайланд болон санхүүгийн үр дүнгийн тайланд хийх толилуулга, түүнчлэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн толилуулгын хамгийн наад захын шаардлагуудыг тогтоодог. Мөн энэ нь холбогдох санхүүгийн тайланд эсвэл тодруулгад толилуулж болох цаашдын зүйлсийг тодорхойлдог. Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлангийн толилуулгын талаархи Стандартын шаардлагуудыг ханган биелүүлэх арга замын талаархи хялбар жишээг энэхүү заавар удирдамжид харуулсан. Байгууллага тус бүрийн тухайн тодорхой нөхцөл байдалд үнэн зөв толилуулгад хүрэхийн тулд шаардлагатай бол толилуулгын дараалал ба мөрийн зүйлсийн хувьд ашигласан утга нэрийг өөрчилж болно. Жишээлбэл; батлан хамгаалах яам гэх мэт улсын секторын байгууллагын мөрийн зүйлс нь төв банкны хувьд хэрэглэх мөрийн зүйлсээс эрс өөр байх магадлалтай байдаг.

ХЗУ6. Уг үлгэрчилсэн санхүүгийн байдлын тайлан нь эргэлтийн ба эргэлтийн бус зүйлсийг хооронд нь ялган заагласнаар санхүүгийн байдлын тайланд толилуулж болох нэг арга замыг харуулсан. Ялган зааглалт нь ойлгомжтой тодорхой бол бусад хэлбэрүүд мөн адил тохиромжтой байж болно.

ХЗУ7. Санхүүгийн тайланг үндэсний засгийн газрын хувьд бэлтгэдэг бөгөөд санхүүгийн үр дүнгийн (чиг үүргээр) тайлан нь Засгийн газрын санхүүгийн статистикт ашигласан, засгийн газрын чиг үүргийн ангиллыг үлгэрчлэн харуулдаг. Ийм чиг үүргийн ангиллыг улсын секторын бүх байгууллагуудад мөрдөх магадлал багатай байдаг. Улсын секторын бусад байгууллагуудад зориулсан илүү ерөнхий чиг үүргийн ангиллын жишээний хувьд энэхүү Стандартыг лавлагаа болгоно.

ХЗУ8. Эдгээр жишээнүүд нь УСНББОУС-ын бүх төлөв байдлыг үлгэрчлэн харуулах зориулалтгүй юм. Эдгээр нь мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын тойм, бусад тайлбар тодруулгыг бас агуулах иж бүрэн санхүүгийн тайланг илэрхийлээгүй болно.

### **Улсын Секторын Байгууллага - Нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдэгдэл (Ишлэл)**

#### *Тайлагнагч байгууллага*

Эдгээр санхүүгийн тайлан нь улсын секторын байгууллагад (А улсын үндэсний засгийн газарт) хамаарна. Санхүүгийн тайлан нь холбогдох хууль тогтоомжинд (Улсын Санхүүгийн Хууль 20XX) заасанчлан, уг тайлагнагч байгууллагыг агуулсан байна. Энэ нь дараах зүйлсээс бүрдэнэ:

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЛИЛУУЛГА

- Төв засгийн газрын яамдууд; ба
- Улсын секторын худалдаа арилжааны байгууллагууд.

### *Санхүүгийн тайлан бэлтгэх суурь*

Санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт зориулагдсан Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарттай нийцсэн байна. Ашигласан хэмжилтийн суурь нь хөрөнгийн дахин үнэлгээний хувьд тохируулга хийсэн түүхэн өртөг юм.

Санхүүгийн тайланг тасралтгүй байх сууриар бэлтгэсэн бөгөөд нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тухайн тайлант үеийн туршид тууштай мөрдсөн болно.

**Улсын секторын байгууллага - Санхүүгийн байдлын тайлан**

**20Х2 оны 12-р сарын 31–ний өдөр**

(мянгачилсан дүнгээр)

	<b>20Х2</b>	<b>20Х1</b>
<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө	X	X
Авлага	X	X
Бараа материал	X	X
Урьдчилж төлсөн төлбөр	X	X
Бусад эргэлтийн хөрөнгө	X	X
	<u>X</u>	<u>X</u>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Авлага	X	X
Хараат байгууллага дахь хөрөнгө оруулалт	X	X
Бусад санхүүгийн хөрөнгө	X	X
Дэд бүтэц ба үндсэн хөрөнгө	X	X
Газар ба барилга	X	X
Биет бус хөрөнгө	X	X
Бусад санхүүгийн бус хөрөнгө	X	X
	<u>X</u>	<u>X</u>
<b>Нийт хөрөнгө</b>	<u>X</u>	<u>X</u>
<b>ӨР ТӨЛБӨР</b>		
<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
Өглөг	X	X
Богино хугацаат зээл	X	X
Урт хугацаат зээлийн тайлант үед төлөх хэсэг	X	X
Богино хугацаат нөөц сан	X	X
Ажилтны тэтгэмж	X	X
Тэтгэвэр, тэтгэмжийн хөтөлбөр <sup>6</sup>	X	X
	<u>X</u>	<u>X</u>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
Өглөг	X	X
Урт хугацаат зээл	X	X
Урт хугацаат нөөц сан	X	X
Ажилтны тэтгэмж	X	X
Тэтгэвэр, тэтгэмжийн хөтөлбөр	X	X
	<u>X</u>	<u>X</u>
<b>Нийт өр төлбөр</b>	<u>X</u>	<u>X</u>
<b>Цэвэр хөрөнгө</b>	<u>X</u>	<u>X</u>

<sup>6</sup> Superannuation-Тэтгэвэр, тэтгэмжийн хөтөлбөр гэдэг нь өөрийн ажилтнуудын тэтгэвэр, тэтгэмжинд зориулан компанийн үүсгэн бий болгосон, тэтгэврийн хөтөлбөр юм. Ред.Ч.Д.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЛИЛУУЛГА

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧ**

Засгийн газрын бусад байгууллагаас оруулсан капитал	X	X
Нөөц сан	X	X
Хуримтлагдсан ашиг/(алдагдал)	X	X
Хяналтын бус хувь оролцоо	X	X
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<u>X</u>	<u>X</u>



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЛИЛУУЛГА

**Улсын секторын байгууллага - 20X2 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жилийн Санхүүгийн үр дүнгийн тайлан**

**(Зардлын ангиллыг чиг үүргээр үлгэрчлэн харуулах)**  
(мянгачилсан дүнгээр)

	<b>20X2</b>	<b>20X1</b>
<b>Орлого</b>		
Татвар	X	X
Хураамж, төлбөр, торгууль, лиценз	X	X
Арилжааны ажил гүйлгээний орлого	X	X
Засгийн газрын бусад байгууллагаас авсан шилжүүлэг	X	X
Бусад орлого	X	X
<b>Нийт орлого</b>	<b>X</b>	<b>X</b>
<b>Зардал</b>		
Нийтийн ерөнхий үйлчилгээ	(X)	(X)
Батлан хамгаалах	(X)	(X)
Нийгмийн хэв журам ба аюулгүй байдал	(X)	(X)
Боловсрол	(X)	(X)
Эрүүл мэнд	(X)	(X)
Нийгмийн хамгаалал	(X)	(X)
Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ	(X)	(X)
Амралт сувилгаа, соёл, шашин	(X)	(X)
Эдийн засгийн асуудлууд	(X)	(X)
Байгаль орчны хамгаалал	(X)	(X)
Бусад зардал	(X)	(X)
Санхүүгийн зардал	(X)	(X)
<b>Нийт зардал</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>
Хараат байгууллагын ашгийн хувь хэсэг <sup>7</sup>	X	X
<b>Тайлант үеийн ашиг/(алдагдал)</b>	<b>X</b>	<b>X</b>
Үүнээс:		
Хяналт тавигч байгууллагын эздэд хамаарах	X	X
Хяналтын бус хувь оролцоонд хамаарах	X	X
	<b>X</b>	<b>X</b>

<sup>7</sup> Энэ нь хараат байгууллагуудын эздэд хамаарах уг хараат байгууллагуудын ашгийн хувь хэсэг гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, энэ нь татвар болон тухайн хараат байгууллагууд дахь хяналтын бус хувь оролцооны дараах дүн байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЛИЛУУЛГА

**Улсын секторын байгууллага - 20X2 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жилийн Санхүүгийн үр дүнгийн тайлан**

**(Зардлын ангиллыг шинж төрлөөр үлгэрчлэн харуулах)**  
(мянгачилсан дүнгээр)

	<b>20X2</b>	<b>20X1</b>
<b>Орлого</b>		
Татвар	X	X
Хураамж, төлбөр, торгууль, лиценз	X	X
Арилжааны ажил гүйлгээний орлого	X	X
Засгийн газрын бусад байгууллагаас авсан шилжүүлэг	X	X
Бусад орлого	X	X
<b>Нийт орлого</b>	<b>X</b>	<b>X</b>
<b>Зардал</b>		
Цалин хөлс ба ажилтны тэтгэмж	(X)	(X)
Буцалтгүй тусламж ба бусад шилжүүлгийн төлбөр	(X)	(X)
Ашигласан хангамжийн материал ба хэрэглээний зүйлс	(X)	(X)
Элэгдэл, хорогдуулгын зардал	(X)	(X)
Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралт <sup>8</sup>	(X)	(X)
Бусад зардал	(X)	(X)
Санхүүгийн зардал	(X)	(X)
<b>Нийт зардал</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>
Хараат байгууллагын ашгийн хувь хэсэг	X	X
<b>Тайлант үеийн ашиг/(алдагдал)</b>	<b>X</b>	<b>X</b>
Үүнээс:		
Хяналт тавигч байгууллагын эздэд хамаарах	X	X
Хяналтын бус хувь оролцоонд хамаарах	X	X
	<b>X</b>	<b>X</b>

<sup>8</sup> Зардлыг шинж төрлөөр ангилдаг санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тусдаа мөрийн зүйл байдлаар харуулдаг. Харин эсрэгээр, зардлыг чиг үүргээр ангилдаг бол үнэ цэнийн бууралтыг түүний хамаарах тухайн чиг үүрэгт (үүргүүдэд) тусган оруулна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЛИЛУУЛГА

Улсын секторын байгууллага - 20X1 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жилийн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянгачилсан дүнгээр)

	Хяналт тавигч байгууллагын эздэд хамаарах				Хяналтын бус хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
	Хувь нийлүүлсэн капитал	Бусад нөөц сан <sup>9</sup>	Хөрвүүлэл-тийн нөөц	Хуримтлагдсан ашиг/(алдагдал)		
20X0 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	X	X	(X)	X	X	X
Няглан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(X)	(X)	(X)	(X)
Тохируулсан үлдэгдэл	X	X	(X)	X	X	X
20X1 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт						
Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний олз		X			X	X
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз		(X)			(X)	(X)
Гадаад үйл ажиллагааны хөрвүүлэлтийн ханшийн зөрүү			(X)		(X)	(X)
Цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн цэвэр орлого		X	(X)		X	X
Тайлант үеийн ашиг				X	X	X
Тайлант үед хүлээн зөвшөөрсөн нийт орлого ба зардал		X	(X)	X	X	X
Дараагийн тайлант үед шилжүүлсэн 20X1 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	X	X	(X)	X	X	X

<sup>9</sup> Хэрэв материаллаг дүнтэй бол бусад нөөц санг тэдгээрийн бүрэлдэхүүн хэсгүүдээр задалж шинжилнэ.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЛИЛУУЛГА

(мянгачилсан дүнгээр)

	Хяналт тавигч байгууллагын эздэд хамаарах				Нийт цэвэр хөрөнгө/өмч
	Хувь нийлүүлсэн капитал	Бусад нөөц сан	Хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан ашиг/(алдагдал)	
	X	X	(X)	X	X
<b>Өмнөх тайлант үеэс шилжүүлэн авсан 20X1 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>					
<b>20X2 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт</b>					
Ул хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний гарз		(X)		(X)	(X)
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний олз		X		X	X
Гадаад үйл ажиллагааны хөрвүүлэлтийн ханшийн зөрүү			(X)	(X)	(X)
Цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн цэвэр орлого		(X)	(X)	(X)	(X)
Тайлант үеийн алдагдал				(X)	(X)
<b>Тайлант үед хүлээн зөвшөөрсөн нийт орлого ба зардал</b>		(X)	(X)	(X)	(X)
<b>20X2 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>(X)</b>	<b>X</b>	<b>X</b>

## НББОУС 1-ТЭЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 1-ийг НББОУС 1 (2003)-ээс үндсэндээ бэлтгэсэн бөгөөд 2008 оны 5 дугаар сард болон 2009 оны 4 дүгээр сард тус тус гаргасан, *СТОУС-ын Сайжруулалтууд*-ын нэг хэсэг байдлаар НББОУС 1-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг үүнд тусгасан болно. Энэ Стандартыг гаргах үед УСНББОУСЗ нь улсын секторын байгууллагуудад *СТОУС 5, Борлуулах Зорилгоор Эзэмшиж Буй Эргэлтийн Бус Хөрөнгө ба Зогсоосон Үйл Ажиллагаа*-ны мөрдөгдөх боломжтой байдлыг харгалзан үзээгүй; иймээс *СТОУС 5*-ыг гаргасны үр дүнд НББОУС 1-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг УСНББОУС 1-д тусгаагүй. УСНББОУС 1 ба НББОУС 1-ийн хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- Тасралтгүй байх ойлголт ухагдахууныг улсын секторын байгууллагуудад мөрдөх талаархи хэлэлцүүлгийг НББОУС 1-ийн хэлэлцүүлэгтэй харьцуулах замаар УСНББОУС 1-д тусган оруулсан.
- НББОУС 1 нь цэвэр хөрөнгө/өмчийн бүх өөрчлөлтийг харуулсан тайлан эсвэл эзэд болохын хувьд тэдний бүрэн эрхийн хүрээнд эзэдтэй хийсэн капиталын ажил гүйлгээ ба эздэд олгосон хуваарилалтаас үүссэнээс бусад, цэвэр хөрөнгө/өмчийн бүх өөрчлөлтийг харуулсан тайлангийн аль нэгийг толилуулахыг зөвшөөрдөг. УСНББОУС 1 нь цэвэр хөрөнгө/өмчийн бүх өөрчлөлтийг харуулсан тайлан толилуулахыг шаарддаг.
- УСНББОУС 1 нь зарим тохиолдолд НББОУС 1-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь УСНББОУС 1 дэх “санхүүгийн үр дүнгийн тайлан” ба “цэвэр хөрөнгө/өмч” гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. НББОУС 1 дэх адилтгах нэр томъёо нь “орлогын тайлан” ба “өмч” юм.
- НББОУС 1-ийн хувьд “орлого” /revenue/ нэр томъёоноос илүү өргөн утгатай байдаг “орлого” /income/ нэр томъёог УСНББОУС 1-д ашигладаггүй.
- *СТОУС, НББОУС, ТБХ/СТОУТХ*-ны Тайлбарыг багтаан агуулах байдлаар “Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (*СТОУС*)”-ыг НББОУС 1-д тодорхойлсон байдаг. Харин УСНББОУС 1 нь “Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт”-ыг ингэж тодорхойлоогүй.
- УСНББОУС 1 нь НББОУС 1 (7-р параграф)-д зааснаас өөр, техникийн нэр томъёоны цогц тодорхойлолтыг агуулсан байдаг.
- УСНББОУС 1 нь санхүүгийн тайланг бэлтгэн гаргах хариуцлагын талаархи тайлбарыг тусгасан байдаг. НББОУС 1 нь үүнтэй адил тайлбарыг (19-20-р параграф) тусгаагүй болно.
- “Үзэл Баримтлалд заасан санхүүгийн тайлангийн зорилго” гэсэн НББОУС 1-ийн адилтгах үг хэллэгийг орлуулахын тулд УСНББОУС 1 нь “энэхүү Стандартад заасан санхүүгийн тайлангийн зорилго” гэсэн үг хэллэгийг ашигласан. Яагаад гэвэл, УСНББОУС-ын хувьд адилтгах Үзэл Баримтлал байдаггүй байсан.

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЛИЛУУЛГА

- УСНББОУС-ын хувьд адилтгах Үзэл Баримтлал байдаггүй байсан учраас УСНББОУС 1 нь санхүүгийн тайлангийн цаг хугацаандаа байх талаархи тайлбарыг тусгасан (69-р параграф).
- УСНББОУС 1 нь орлого, зардлын зүйлсийг санхүүгийн үр дүнгийн тайланд эсвэл тодруулгад онцгой шинжтэй зүйлс гэж толилуулахыг илт хориглодоггүй. НББОУС 1 нь орлого, зардлын аливаа зүйлсийг орлогын тайланд эсвэл тодруулгад онцгой шинжтэй зүйлс гэж толилуулахыг хориглодог.
- Бусад УСНББОУС-д заасан шилжилтийн нөхцлийг мөрдсөний үр дүнд санхүүгийн тайланд тусгаагүй зүйлсийн тодруулга хийхгүй байхыг зөвшөөрсөн шилжилтийн нөхцлийг УСНББОУС 1 агуулсан байдаг (151-р параграф).

## УСНББОУС 2-МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) 7, *Мөнгөн Гүйлгээний Тайлан*-гаас үндсэндээ бэлтгэсэн болно. НББОУС 7-гоос авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон ЕС4М 6ХН, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)

Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.

## УСНББОУС 2-МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

### УСНББОУС-ын түүх

Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

УСНББОУС 2, Мөнгөн Гүйлгээний Тайлан-г 2000 оны 5 дугаар сард гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 2-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 37, Хамтын Хэлэлцээр (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 35, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 3, Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа (2006 оны 12 дугаар сард гаргасан)
- УСНББОУС 4, Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө (2006 оны 12 дугаар сард гаргасан)
- УСНББОУС-ын Сайжруулалтууд (2010 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС-ын Сайжруулалтууд (2010 оны 11 дүгээр сард гаргасан)

### УСНББОУС 2-ын нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт

Өөрчлөгдсөн параграф	Хэрхэн өөрчилсөн	Юугаар өөрчилсөн
3	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
4	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
8	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
16	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
22	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
25	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар



МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

27	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
30	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
36	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 4, 2006 оны 12-р сар
37	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 4, 2006 оны 12-р сар
40	Хассан	УСНББОУС 3, 2006 оны 12-р сар УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
41	Хассан	УСНББОУС 3, 2006 оны 12-р сар
42	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
43	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
47	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
48	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар
50А	Шинэ	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
52А	Шинэ	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
52Б	Шинэ	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
61	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар
63А	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар
63Б	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
63В	Шинэ	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
63Г	Шинэ	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
63Д	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
64	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
ҮЖ	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 3, 2006 оны 12-р сар

**УСНББОУС 2–МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**АГУУЛГА**

	Параграф
Зорилго	
Цар хүрээ	1-4
Мөнгөн гүйлгээний мэдээллийн ач холбогдол	5-7
Тодорхойлолт	8-17
Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө	9-11
Эдийн засгийн нэгдмэл байгууллага	12-14
Ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи	15
Улсын Үйлдвэрийн Газар	16
Цэвэр хөрөнгө/Өмч	17
Мөнгөн гүйлгээний тайлангийн толилуулга	18-26
Үндсэн үйл ажиллагаа	21-24
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа	25
Санхүүгийн үйл ажиллагаа	26
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний тайлагнал	27-30
Хөрөнгө оруулалтын болон санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний тайлагнал	31
Мөнгөн гүйлгээг цэвэр сууриар тайлагнах	32-35
Гадаад валютаар гарсан мөнгөн гүйлгээ	36-39
Хүү, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт	40-43
Орлогын албан татвар	44-46
Хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалт	47-48
Хяналтанд буй байгууллагууд болон үйл ажиллагааны бусад нэгжүүдийн худалдан авалт ба данснаас хасалт	49-53
Мөнгөн бус ажил гүйлгээ	54-55
Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгүүд	56-58
Бусад тодруулга	59-62
Хүчин төгөлдөр болох хугацаа	63-64
Үлгэрчилсэн жишээ	
НББОУС 7-той харьцуулалт	

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 2, *Мөнгөн Гүйлгээний Тайлан*-г зорилго хэсэг болон 1-64-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 2-ыг түүний зорилгын агуулга, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

Мөнгөн гүйлгээний тайлан нь (а) мөнгөн орлогын гүйлгээний эх үүсвэр, (б) тайлант үеийн туршид мөнгийг зарцуулсан зүйлс, (в) тухайн тайлангийн өдрөөрх мөнгөний үлдэгдлийг тодорхойлдог. Байгууллагын мөнгөн гүйлгээний талаархи мэдээлэл нь тайлагнах ба шийдвэр гаргах хоёр зорилгын аль алины хувьд санхүүгийн тайлан хэрэглэгчдийг мэдээллээр хангахад ач холбогдолтой байдаг. Мөнгөн гүйлгээний мэдээлэл нь өөрийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд шаардлагатай мөнгийг улсын секторын байгууллага хэрхэн босгосон ба тэрхүү мөнгийг ашиглан зарцуулсан арга маягийг тодорхойлох боломжийг хэрэглэгчдэд олгодог. Байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдал гэх мэт нөөцийн хуваарилалтын талаархи шийдвэрийг гаргаж, үнэлэхийн тулд хэрэглэгчид нь мөнгөн гүйлгээний хугацаа ба магадлалын талаар ойлголт олж авах шаардлагатай байдаг. Энэ Стандартын зорилго нь мөнгөн гүйлгээг тайлант үед үндсэн үйл ажиллагаанаас, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас, санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн гэдгээр ангилсан, мөнгөн гүйлгээний тайлангийн тусламжтайгаар тухайн байгууллагын мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийн түүхэн өөрчлөлтийн талаархи мэдээллээр хангахад оршино.

## Цар хүрээ

- Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь мөнгөн гүйлгээний тайланг энэхүү Стандартын шаардлагуудын дагуу бэлтгэх бөгөөд тухайн санхүүгийн тайланг толилуулах тайлант үе тус бүрийн санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг байдлаар толилуулна.**
- Мөнгөн гүйлгээний талаархи мэдээлэл нь (а) байгууллагын мөнгөн гүйлгээг үнэлэх, (б) хууль тогтоомж болон зохицуулалттай (үүнд: тохиромжтой тохиолдолд батлагдсан төсөвтэй) тухайн байгууллагын нийцэлтийг үнэлэх, (в) байгууллагыг нөөцөөр хангах буюу түүнтэй ажил гүйлгээ хийх эсэх талаархи шийдвэрийг гаргахад уг байгууллагын санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ач холбогдолтой байж болно. Санхүүгийн тайлангийн хэрэглэгчид нь тухайн байгууллага мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийг хэрхэн үүсгэн бий болгож, хэрхэн зарцуулж байгааг сонирхдог. Ийм сонирхол нь байгууллагын үйл ажиллагааны шинж төрлөөс хамаарахгүй, мөн түүнчлэн мөнгийг тухайн байгууллагын тухайлбал, улсын санхүүгийн байгууллагын бүтээгдэхүүн гэж үзэх эсэхээс үл хамаарна. Хэдийгээр байгууллагуудын орлого бий болгох үндсэн үйл ажиллагаа нь ялгаатай байж болох боловч тэдэнд бараг ижил шалтгаанаар мөнгө хэрэгцээтэй байдаг. Байгууллагууд нь хэрэглэн зарцуулсан бараа, үйлчилгээнийхээ үнийг төлөх, өрийн байнгын үйлчилгээний зардлыг төлөх, зарим тохиолдолд өрийн хэмжээг бууруулахад мөнгө шаардлагатай байдаг. Иймээс энэ Стандарт нь мөнгөн гүйлгээний тайлан бэлтгэж, толилуулахыг бүх байгууллагаас шаарддаг.
- [Хассан]
- [Хассан]

## Мөнгөн гүйлгээний мэдээллийн ач холбогдол

5. Байгууллагын мөнгөн гүйлгээний талаархи мэдээлэл нь (а) байгууллагын ирээдүйн мөнгөний хэрэгцээ шаардлага, (б) ирээдүйд мөнгөн гүйлгээг бий болгох түүний чадвар, (в) өөрийн үйл ажиллагааны цар хүрээ ба шинж төрлийн өөрчлөлтийг санхүүжүүлэх түүний чадварыг урьдчилан таамаглахад хэрэглэгчдэд туслалцаа үзүүлэх ач холбогдолтой юм. Мөнгөн гүйлгээний тайлан нь тайлант үеийн турш дахь мөнгөн орлогын болон мөнгөн зарлагын гүйлгээний талаархи өөрийн тайлагналын хариуцлагыг тухайн байгууллага биелүүлэх арга хэрэгслээр бас хангадаг.
6. Бусад санхүүгийн тайлангийн хамт ашиглах тохиолдолд мөнгөн гүйлгээний тайлан нь байгууллагын цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, түүний санхүүгийн бүтэц (үүн дотроо хөрвөх чадвар ба төлбөрийн чадвар), түүнчлэн өөрчлөгдөж буй нөхцөл байдал ба боломжуудад зохицохын тулд мөнгөн гүйлгээний дүн, хугацаанд нөлөөлөх уг байгууллагын чадварыг үнэлэх боломжийг хэрэглэгчдэд олгох тийм мэдээллээр хангадаг. Мөн энэ нь нэг ижил ажил гүйлгээ ба бусад үйл явдлыг бүртгэхдээ нягтлан бодох бүртгэлийн янз бүрийн аргууд ашигласны үр нөлөөг арилгадаг учраас өөр өөр байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнгийн тайлагналын зэрэгцүүлэгдэх боломжит байдлыг нэмэгдүүлдэг.
7. Ирээдүйн мөнгөн гүйлгээний дүн, хугацаа, магадлалыг илэрхийлэх үзүүлэлт болгон мөнгөн гүйлгээний түүхэн мэдээллийг ихэвчлэн ашигладаг. Энэ нь мөн ирээдүйн мөнгөн гүйлгээний талаархи өмнөх үнэлгээний оновчтой байдлыг шалгахад ач холбогдолтой байдаг.

## Тодорхойлолт

8. **Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:**

**Мөнгө** нь бэлэн мөнгө ба харилцах данснаас бүрдэнэ.

**Мөнгөтэй адилтгах хөрөнгө** нь үнэ цэнийн өөрчлөлтийн маш бага эрсдэлтэй, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хөрвөх боломжтой богино хугацаат, ихээхэн өндөр хөрвөх чадвартай хөрөнгө оруулалт юм.

**Мөнгөн гүйлгээ** нь мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийн орлогын болон зарлагын урсгал юм.

**Хяналт:** Байгууллага нь бусад байгууллага дахь өөрийн оролцооноос үүсэх өгөөжийн хувьсан өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээдэг эсвэл тэрхүү өгөөжийг хүртэх эрхтэй бөгөөд уг бусад байгууллага дахь бүрэн эрхээрээ дамжуулан тэдгээр өгөөжийн шинж төрөл буюу дүнд нөлөө үзүүлэх чадвар, боломжтой бол тухайн байгууллага нь тэрхүү бусад байгууллагыг хянана.

**Санхүүгийн үйл ажиллагаа** нь байгууллагын хувь нийлүүлсэн капитал ба зээлийн бүтэц, хэмжээнд өөрчлөлт оруулах үр дүн бүхий үйл ажиллагаа юм.

**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа** нь мөнгөтэй адилтгах хөрөнгөнд хамаарахгүй урт хугацаат хөрөнгө ба бусад хөрөнгө оруулалтыг худалдан авах болон данснаас хасах үйл ажиллагаа юм.

**Үндсэн үйл ажиллагаа** нь байгууллагын хөрөнгө оруулалтын болон санхүүгийн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаа юм.

**Тайлангийн өдөр** гэдэг нь тухайн санхүүгийн тайлангийн хамаарах тайлант үеийн сүүлчийн өдөр байна.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д дахин нийтэлсэн болно.

#### **Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө**

9. Хөрөнгө оруулалтын буюу бусад зорилго гэхээс илүүтэйгээр мөнгөний богино хугацааны хариуцлагаа биелүүлэх зорилгоор мөнгөтэй адилтгах хөрөнгийг эзэмшдэг. Мөнгөтэй адилтгах хөрөнгийн шалгуурыг хангахын тулд хөрөнгө оруулалт нь мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хөрвөх боломжтой бөгөөд үнэ цэнийн өөрчлөлтийн маш бага эрсдэлтэй байх ёстой. Иймээс хөрөнгө оруулалт нь богино хугацаатай, тодруулбал; худалдан авч эзэмшсэнээс хойш 3 сар буюу түүнээс богино хугацаанд дуусгавар болох хугацаатай байх зөвхөн тийм тохиолдолд мөнгөтэй адилтгах хөрөнгийн шалгуурыг ихэвчлэн хангадаг. Мөн чанарын хувьд мөнгөтэй адилтгах хөрөнгө байхаас бусад тохиолдолд өмчийн хөрөнгө оруулалтыг мөнгөтэй адилтгах хөрөнгөнд оруулахгүй.
10. Банкны зээлийг ерөнхийдөө санхүүгийн үйл ажиллагаанд хамаарна гэж үздэг. Гэвч шаардлагаар шууд буцаан төлөгдөх банкны овердрафт нь зарим улс оронд тухайн байгууллагын мөнгөн хөрөнгийн удирдлагын салшгүй нэг хэсэг болдог. Энэ тохиолдолд банкны овердрафтыг мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийн бүрэлдэхүүнд оруулдаг. Банкны ийм хэлцлүүдийн онцлог шинж нь банкны дансны үлдэгдлийг эерэг дүнгээс сөрөг дүн болж байнга хэлбэлзэхэд хүргэдэг явдал юм.
11. Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийг бүрдүүлж буй зүйлс нь байгууллагын үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны, санхүүгийн үйл ажиллагааны хэсэг гэхээсээ илүүтэйгээр тухайн байгууллагын мөнгөн хөрөнгийн удирдлагын бүрэлдэхүүн хэсэг болдог тул тэдгээр зүйлсийн хоорондох хөдөлгөөнийг мөнгөн гүйлгээнд оруулдаггүй. Мөнгөтэй адилтгах хөрөнгөнд илүүдэл мөнгөөр хийх хөрөнгө оруулалт нь мөн мөнгөн хөрөнгийн удирдлагад хамаардаг.

### **Эдийн засгийн нэгдмэл байгууллага**

12. Хяналт тавигч байгууллага ба түүний хяналтанд буй аливаа байгууллагуудаас бүрдэх байгууллагуудын группыг санхүүгийн тайлагналын зорилгоор тодорхойлохын тулд энэ Стандартад эдийн засгийн нэгдмэл байгууллага гэсэн нэр томъёог ашигласан.
13. Эдийн засгийн нэгдмэл байгууллагыг илэрхийлэхийн тулд зарим үед захиргааны байгууллага, санхүүгийн байгууллага, нэгтгэсэн байгууллага, групп гэх мэт нэр томъёог ашигладаг.
14. Эдийн засгийн нэгдмэл байгууллага нь нийгмийн бодлогын болон арилжааны аль аль зорилго бүхий байгууллагуудыг агуулсан байж болно. Жишээлбэл; төрийн орон сууцны удирдах газар нь нэрлэсэн хөлстэйгээр орон байраар хангадаг байгууллагууд, түүнчлэн арилжааны зорилгоор орон сууцаар хангадаг байгууллагуудын аль алиныг агуулсан, эдийн засгийн нэгдмэл байгууллага байж болно.

### **Ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи**

15. Хөрөнгө нь өөрийнхөө зорилтонд хүрэх арга хэрэгслээр байгууллагыг хангадаг. Байгууллагын зорилтын дагуу бараа, үйлчилгээг нийлүүлэхэд ашигладаг боловч цэвэр мөнгөн орлогын гүйлгээг шууд үүсгэн бий болгодоггүй хөрөнгүүдийг “үйлчилгээний чадавхи агуулсан” гэж ихэвчлэн нэрлэдэг. Цэвэр мөнгөн орлогын гүйлгээг бий болгоход ашигладаг хөрөнгүүдийг “ирээдүйн эдийн засгийн үр өгөөж агуулсан” гэж ихэвчлэн нэрлэдэг. Хөрөнгийг ашиглаж болох бүх зорилгыг нэгтгэн илэрхийлэхийн тулд энэ Стандарт нь хөрөнгүүдийн чухал шинж чанаруудыг тодорхойлох үүднээс “ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи” гэсэн нэр томъёог ашигласан.

### **Улсын Үйлдвэрийн Газар**

16. [Хассан]

### **Цэвэр хөрөнгө/Өмч**

17. Цэвэр хөрөнгө/өмч нь санхүүгийн байдлын тайлан дахь үлдэх хэмжүүрийг (хөрөнгөөс өр төлбөрийг хасах) илэрхийлэхийн тулд энэ Стандартад ашигласан нэр томъёо юм. Цэвэр хөрөнгө/өмч нь эерэг эсвэл сөрөг утгатай байж болно. Хэрэв утга нь ойлгомжтой бол цэвэр хөрөнгө/өмчийн оронд өөр нэр томъёог ашиглаж болно.

### **Мөнгөн гүйлгээний тайлангийн толилуулга**

18. Мөнгөн гүйлгээний тайлан нь тухайн тайлант үеийн туршид гарсан мөнгөн гүйлгээг үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны, санхүүгийн үйл ажиллагааны гэдгээр ангилж, тайлагнадаг.

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

19. Байгууллага нь үндсэн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн гүйлгээг өөрийн үйл ажиллагаанд хамгийн тохиромжтой арга маягаар толилуулна. Үйл ажиллагаагаар хийх ийм ангилал нь тухайн байгууллагын санхүүгийн байдал, түүний мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийн дүнд тэдгээр үйл ажиллагааны үзүүлэх нөлөөг үнэлэх боломжийг хэрэглэгчдэд олгох тийм мэдээллээр хангадаг. Мөн эдгээр үйл ажиллагааны харилцан хамаарлыг үнэлж дүгнэхийн тулд ийм мэдээллийг ашиглаж болох юм.
20. Нэг ажил гүйлгээ нь өөр өөр байдлаар ангилагдах мөнгөн гүйлгээнүүдийг агуулсан байж болно. Жишээлбэл, зээлийг буцаан төлөх мөнгө нь хүү ба үндсэн төлбөрийн аль алины агуулах тохиолдолд төлбөрийн хүүний хэсгийг үндсэн үйл ажиллагааны, зээлийн үндсэн төлбөрийг санхүүгийн үйл ажиллагааны гэж ангилж болох юм.

### Үндсэн үйл ажиллагаа

21. Үндсэн үйл ажиллагаанаас үүсэх цэвэр мөнгөн гүйлгээний дүн нь тухайн байгууллагын үйл ажиллагааг дараах байдлаар санхүүжүүлсэн хэмжээг илэрхийлэх гол үзүүлэлт юм:

- (а) (шууд ба шууд бус) татвараар; эсвэл
- (б) тухайн байгууллагын нийлүүлсэн бараа, үйлчилгээг хүлээн авагчдаар.

Цэвэр мөнгөн гүйлгээний дүн нь үйл ажиллагааны хүчин чадлыг хэвээр хадгалах, зээлийг буцаан төлөх, өөрийн эздэд ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг төлөх, санхүүжилтийн гадаад эх үүсвэрээс мөнгө авахгүйгээр шинэ хөрөнгө оруулалтуудыг хийх тухайн байгууллагын чадвар, боломжийг харуулахад мөн туслалцаа үзүүлдэг. Бүхэлдээ засгийн газрын түвшинд нэгтгэсэн, үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ нь өөрийн одоогийн үйл ажиллагааг Засгийн газар татвар болон төлбөрөөр санхүүжүүлсэн хэмжээг илэрхийлэх үзүүлэлтээр хангадаг. Үндсэн үйл ажиллагааны урьд өмнөх түүхэн мөнгөн гүйлгээний тодорхой бүрдэл хэсгүүдийн талаархи мэдээлэл нь бусад мэдээллийн хамтаар уг үндсэн үйл ажиллагааны ирээдүйн мөнгөн гүйлгээг прогнозчилоход ач холбогдолтой байдаг.

22. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ нь юуны өмнө тухайн байгууллагын мөнгө бий болгох үндсэн үйл ажиллагаанаас үүсдэг. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний жишээг доор дурдав:

- (а) Татвар, хураамж, торгуулиас бий болсон мөнгөн орлого;
- (б) Тухайн байгууллагын нийлүүлсэн бараа, үйлчилгээний төлбөрөөс орсон мөнгөн орлого;
- (в) Буцалтгүй тусламж буюу шилжүүлэг ба төв засгийн газар эсвэл улсын секторын бусад байгууллагуудаас олгосон бусад



## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

хуваарилалт болон төсвийн бусад эрх мэдлээс үүссэн мөнгөн орлого;

- (г) Эрхийн шимтгэл, төлбөр, хураамж ба бусад орлогоос бий болсон мөнгөн орлого;
- (д) Улсын секторын бусад байгууллагуудад тэдгээрийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулан олгосон мөнгөн төлбөр (үүнд: зээл хамаарахгүй);
- (е) Бараа, үйлчилгээний хувьд бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн мөнгөн төлбөр;
- (ж) Ажиллагчдад төлсөн эсвэл тэдний өмнөөс төлсөн мөнгөн төлбөр;
- (и) Даатгалын байгууллагын даатгалын хураамж, хохирлын төлбөр, аннуити болон даатгалын гэрээний бусад үр өгөөжийн мөнгөн орлого ба мөнгөн төлбөр;
- (к) Үндсэн үйл ажиллагаанд хамаарах үл хөдлөх орон нутгийн татвар эсвэл орлогын албан татварын (хамааралтай бол) мөнгөн төлбөр;
- (л) Худалдаа буюу арилжааны зорилготой гэрээнээс үүссэн мөнгөн орлого ба мөнгөн төлбөр;
- (м) Зогсоосон үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн орлого буюу мөнгөн төлбөр; ба
- (н) Зарга, маргааны барагдуулалттай холбоотой мөнгөн орлого буюу мөнгөн төлбөр;

Үндсэн хөрөнгийн борлуулалт гэх мэт зарим ажил гүйлгээ нь олз эсвэл гарз үүсгэх ба түүнийг ашиг, алдагдалд тусган оруулж болох юм. Ийм ажил гүйлгээтэй холбоотой мөнгөн гүйлгээ нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ юм. Харин УСНББОУС 17 *Үндсэн Хөрөнгө*-ийн 83А параграфт заасан, бусдад түрээслэх ба дараа нь борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийг барьж байгуулах эсвэл худалдан авахад төлсөн мөнгөн төлбөр нь үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ болно. Ийм хөрөнгийн түрээслэлт болон цаашдын борлуулалтаас үүссэн мөнгөн орлого нь мөн үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ болох юм.

- 23. Байгууллага нь үнэт цаас болон зээлийг арилжаа буюу худалдааны зорилгоор эзэмшиж болох бөгөөд энэ тохиолдолд тэдгээр нь буцаан борлуулах зорилгоор тусгайлан худалдан авсан бараа материалтай ижил байдаг. Иймээс арилжаа буюу худалдааны зорилготой үнэт цааснуудын худалдан авалтг, борлуулалтаас үүссэн мөнгөн гүйлгээг үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ гэж ангилдаг. Үүнтэй адилаар, санхүүгийн байгууллагаас олгосон мөнгөн урьдчилгаа ба зээл нь тухайн байгууллагын мөнгө бий болгох гол үйл ажиллагаатай холбоотой учраас тэдгээрийг ихэвчлэн үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ гэж ангилдаг.
- 24. Зарим улс оронд, засгийн газар буюу улсын секторын бусад байгууллагууд нь тухайн байгууллагын үйл ажиллагааг санхүүжүүлэхийн

тулд төсөв хуваарилах буюу мөнгө сангийн эрх олгодог боловч тэдгээр мөнгө санг урсгал үйл ажиллагаанд, капитал ажилд болон хувь нийлүүлсэн капиталд хуваарилан зарцуулах талаар тодорхой ялган заагаагүй байдаг. Байгууллага нь төсвийн хуваарилалт буюу төсвийн эрхийг урсгал үйл ажиллагаа, капитал ажил, хувь нийлүүлсэн капитал гэдгээр тус тусад нь ялган тодорхойлох боломжгүй тохиолдолд уг төсвийн хуваарилалт буюу төсвийн эрхийг үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ байдлаар ангилах бөгөөд санхүүгийн тайлангийн тодруулгад энэ тухай тодруулга хийнэ.

### **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа**

25. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ нь тухайн байгууллагын ирээдүйн үйлчилгээ нийлүүлэлтэнд хувь нэмрээ оруулах нөөцийн хувьд зарцуулсан мөнгөн зарлагын гүйлгээний дүнг илэрхийлдэг учраас хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг тусдаа толилуулах нь чухал ач холбогдолтой байдаг. Санхүүгийн байдлын тайланд хөрөнгө хүлээн зөвшөөрөхөд хүргэх зөвхөн тийм мөнгөн зарлага нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа гэж ангилагдах шалгуурыг хангах юм. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн гүйлгээний жишээнд дараах зүйлс хамаарна:

- (а) Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө болон бусад урт хугацаат хөрөнгийг худалдан авахад төлсөн мөнгө. Капиталжуулсан хөгжүүлэлтийн зардал болон өөрөө барьж байгуулсан үндсэн хөрөнгөтэй холбоотой төлбөрүүд нь энэхүү дүнд хамаарна;
- (б) Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө болон бусад урт хугацаат хөрөнгийг борлуулсны мөнгөн орлого;
- (в) Бусад байгууллагуудын өмчийн буюу өрийн хэрэглүүр болон хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоог худалдан авахад төлсөн мөнгөн төлбөр (мөнгөтэй адилтгах хөрөнгө гэж үзэх хэрэглүүр эсвэл худалдаа, арилжааны зорилгоор эзэмшиж буй хэрэглүүрийн хувьд төлснөөс бусад мөнгөн төлбөр);
- (г) Бусад байгууллагуудын өмчийн буюу өрийн хэрэглүүр болон хамтарсан үйлдвэр дэх хувь оролцооны борлуулалтаас үүссэн мөнгөн орлого (мөнгөтэй адилтгах хөрөнгө гэж үзэх хэрэглүүр болон худалдаа, арилжааны зорилгоор эзэмшиж буй хэрэглүүрээс үүссэнээс бусад мөнгөн орлого);
- (д) Бусад талуудад олгосон зээл ба мөнгөн урьдчилгаа (улсын санхүүгийн байгууллагаас олгосон зээл ба мөнгөн урьдчилгаанаас бусад);
- (е) Бусад талуудад олгосон зээл ба мөнгөн урьдчилгааны буцаан төлөлтөөс хүлээн авсан мөнгө орлого (улсын санхүүгийн байгууллагын зээл ба мөнгөн урьдчилгаанаас бусад);
- (ж) Худалдаа, арилжааны зорилгоор эзэмшиж байгаа гэрээ эсвэл мөнгөн төлбөрүүдийг нь санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

гүйлгээ гэж ангилснаас бусад тохиолдолд фьючерс гэрээ, форвард гэрээ, опционы гэрээ, свопын гэрээний хувьд төлсөн мөнгө төлбөр; ба

- (и) Худалдаа, арилжааны зорилгоор эзэмшиж байгаа гэрээ эсвэл мөнгөн орлогуудыг нь санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ гэж ангилснаас бусад тохиолдолд фьючерс гэрээ, форвард гэрээ, опционы гэрээ, свопын гэрээнээс үүссэн мөнгө орлого.

Гэрээг тодорхойлж болох төлөв байдлын хейж гэж тайлагнасан тохиолдолд уг гэрээний мөнгөн гүйлгээг тухайн хейж хийж буй төлөв байдлын мөнгөн гүйлгээтэй ижил арга замаар ангилна.

### Санхүүгийн үйл ажиллагаа

26. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ нь тухайн байгууллагад капитал нийлүүлэгчдийн зүгээс ирээдүйн мөнгөн гүйлгээнд тавих шаардлагыг урьдчилан таамаглахад ач тустай тул санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг тусдаа толилуулах нь чухал ач холбогдолтой байдаг. Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн гүйлгээний жишээнд дараах зүйлс хамаарна:

- (а) Баталгаагүй өрийн бичиг, зээл, баталгаат өрийн бичиг, бонд, моргейжийн (үл хөдлөх хөрөнгийн барьцаат) болон бусад богино буюу урт хугацаат зээллэгийн хэрэглүүрийн гаргалтаас хүлээн авсан мөнгөн орлого;
- (б) Зээлийг буцаан төлөх мөнгөн төлбөр;
- (в) Санхүүгийн түрээстэй холбоотой төлөгдөөгүй өр төлбөрийн бууралт болгон түрээслэгчийн төлсөн мөнгөн төлбөр.

### Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний тайлагнал

27. **Байгууллага нь үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг дараах аргын аль нэгийг ашиглан тайлагнана:**

- (а) **Шууд арга, энд нийт мөнгөн орлого ба нийт мөнгөн зарлагыг гол ангиудаар толилуулдаг; эсвэл**
- (б) **Шууд бус арга, энд мөнгөн бус шинжтэй ажил гүйлгээ, өнгөрсөн эсвэл ирээдүйн үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого буюу төлбөрийн аливаа хойшлуулалт эсвэл хуримтлуулалтын үр нөлөө, түүнчлэн хөрөнгө оруулалтын болон санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээтэй холбоотой орлого, зардлын зүйлсийн хувьд ашиг, алдагдлыг тохируулдаг.**

28. Байгууллагууд нь шууд аргыг ашиглан үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг тайлагнахыг дэмжинэ. Шууд арга нь (а) ирээдүйн мөнгөн гүйлгээг тооцоолоход ач холбогдолтой байж болох, (б) шууд бус аргын дагуу харуулах боломжгүй мэдээллээр хангадаг. Шууд аргын дагуу нийт мөнгөн

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

орлого ба нийт мөнгөн зарлагын гол ангиудын талаархи мэдээллийг дараах хоёр хувилбарын аль нэгээр олж авч болох юм:

- (а) Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бүртгэлүүдээс; эсвэл
- (б) Доорх зүйлсийн хувьд үндсэн үйл ажиллагааны орлого, үндсэн үйл ажиллагааны зардал (улсын санхүүгийн байгууллагын хувьд хүү ба түүнтэй адилтгах орлого, хүүний зардал ба түүнтэй адилтгах зардал) болон санхүүгийн үр дүнгийн тайлан дахь бусад зүйлсийг тохируулах замаар;
  - (i) тайлант үеийн туршид бараа материал, үндсэн үйл ажиллагааны авлага ба өглөгт гарсан өөрчлөлтүүд;
  - (ii) бусад мөнгөн бус зүйлс; ба
  - (iii) мөнгөн үр нөлөө нь хөрөнгө оруулалтын эсвэл санхүүгийн мөнгөн гүйлгээ байх бусад зүйлс.

29. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг шууд аргаар тайлагнаж буй байгууллагууд нь ердийн үйл ажиллагааны ашиг, алдагдлыг уг үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээтэй уялдуулах тохируулгын тайлан бэлтгэхийг мөн дэмжинэ. Энэхүү тохируулгыг мөнгөн гүйлгээний тайлангийн нэг хэсэг байдлаар эсвэл санхүүгийн тайлангийн тодруулгад харуулж болно.

30. Шууд бус аргын үед дараах зүйлсийн үр нөлөөний хувьд ашиг, алдагдлыг тохируулах замаар үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээг тодорхойлдог:

- (а) Тайлант үеийн туршид бараа материал, үндсэн үйл ажиллагааны авлага ба өглөгт гарсан өөрчлөлтүүд;
- (б) Элэгдэл, нөөц сан, хойшлогдсон татвар, гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит бус олз ба гарз, хараат байгууллагын хуваарилагдаагүй ашиг гэх мэт мөнгөн бус зүйлс; ба
- (в) Мөнгөн үр нөлөө нь хөрөнгө оруулалтын эсвэл санхүүгийн мөнгөн гүйлгээ байх бусад бүх зүйлс.
- (г) [Хассан]

### **Хөрөнгө оруулалтын болон санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний тайлагнал**

31. Байгууллага нь 32 ба 35-р параграфт дурдсан, цэвэр сууриар тайлагнасан мөнгөн гүйлгээнээс бусад, хөрөнгө оруулалтын болон санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн нийт мөнгөн орлого ба нийт мөнгөн зарлагын гол ангиудыг тус тусад нь тайлагнана.

## **Мөнгөн гүйлгээг цэвэр сууриар тайлагнах**

32. **Дараах үндсэн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг цэвэр дүнгээр тайлагнаж болно:**
- (a) **Мөнгөн гүйлгээ нь тухайн байгууллагын биш, харин өөр бусад талын үйл ажиллагааг тусган илэрхийлэх тохиолдолд үйлчлүүлэгч, татвар төлөгч, тэтгэмж авагчийн өмнөөс цуглуулсан мөнгөн орлого ба төлсөн мөнгөн төлбөр;**
  - (б) **Хурдан эргэлттэй, их дүнтэй, дуусгавар болох богино хугацаатай зүйлсэд хамаарах мөнгөн орлого ба төлбөр.**
33. 32(а) параграф нь уг үр дүн болох мөнгөн гүйлгээг тухайн тайлагнагч байгууллага хянадаг зөвхөн тийм ажил гүйлгээнд хамаарна. Ийм мөнгөн орлого ба төлбөрийн жишээнд дараах зүйлс хамаарна:
- (a) Засгийн газрын аль түвшний байгууллага нь засгийн газрын өөр нэг түвшний байгууллагын өмнөөс цуглуулсан татвар, үүнд: татварыг хуваах хэлцлийн нэг хэсэг байдлаар өөрийн хэрэглээнд зориулан засгийн газрын цуглуулсан татвар хамаарахгүй;
  - (б) Улсын санхүүгийн байгууллагын харилцах дансны хүлээн авалт ба түүний буцаан төлөлт;
  - (в) Хөрөнгө оруулалтын буюу итгэмжлэлийн байгууллага нь үйлчлүүлэгчдийн өмнөөс эзэмшиж буй мөнгө сан;
  - (г) Үл хөдлөх хөрөнгийн эздийн өмнөөс цуглуулсан ба тэдэнд төлсөн түрээсийн төлбөр.
34. Дээрх 32 (б) параграфт дурдсан, мөнгөн орлого ба төлбөрийн жишээнд дараах зүйлсийн хувьд төлсөн урьдчилгаа ба түүний буцаан төлөлт хамаарна:
- (a) Хөрөнгө оруулалтын худалдан авалт ба борлуулалт;
  - (б) Бусад богино хугацаат зээл, тухайлбал, гурван сар буюу түүнээс богино дуусгавар хугацаатай зээл.
35. **Улсын санхүүгийн байгууллагын дараах үйл ажиллагаа тус бүрээс үүссэн мөнгөн гүйлгээг цэвэр дүнгээр тайлагнаж болно:**
- (a) **Дуусгавар болох тогтмол хугацаатайгаар байршуулсан мөнгөний хүлээн авалт ба буцаан төлөлтөнд хамаарах мөнгөн орлого болон мөнгөн төлбөр;**
  - (б) **Бусад санхүүгийн байгууллагад мөнгө байршуулалт ба түүнийг буцаан таталт;**
  - (в) **Үйлчлүүлэгчдэд олгосон мөнгөн урьдчилгаа ба зээл, тэдгээр урьдчилгаа болон зээлийн буцаан төлөлт.**

## Гадаад валютаар гарсан мөнгөн гүйлгээ

36. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээнээс үүссэн мөнгөн гүйлгээг тухайн байгууллагын бүртгэлийн валютаар бүртгэнэ. Ингэхдээ уг мөнгөн гүйлгээ гарсан өдрөөрх гадаад валют ба бүртгэлийн валютын хоорондох ханшаар тэрхүү гадаад валютыг хөрвүүлж, бүртгэлийн валютаар илэрхийлнэ.
37. Гадаад дахь хяналтанд буй байгууллагын мөнгөн гүйлгээг тухайн мөнгөн гүйлгээний өдрөөрх бүртгэлийн валют ба гадаад валютын хоорондох ханшаар хөрвүүлнэ.
38. Гадаад валютаар гарсан мөнгөн гүйлгээг УСНББОУС 4, *Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө*-тэй нийцэх тийм арга маягаар тайлагнана. Ийм арга маяг нь бодит ханштай ойролцоо ханш ашиглахыг зөвшөөрдөг. Жишээлбэл; гадаад валютаар гарсан ажил гүйлгээг бүртгэх эсвэл гадаад дахь хяналтанд буй байгууллагын мөнгөн гүйлгээг хөрвүүлэхдээ тайлант үеийн жинэлсэн дундаж ханшийг ашиглаж болох юм. Харин УСНББОУС 4 нь гадаад дахь хяналтанд буй байгууллагын мөнгөн гүйлгээг хөрвүүлэхдээ тухайн тайлант үеийн эцэс дэх ханш ашиглахыг зөвшөөрдөггүй.
39. Гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн хэрэгжээгүй олз, гарз нь мөнгөн гүйлгээ биш юм. Гэхдээ, тайлант үеийн эхэн болон эцэс дэх мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийн үлдэгдлийг тохируулахын тулд гадаад валютаар эзэмшиж байгаа эсвэл гадаад валютаар төлөх мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгөнд ханшийн өөрчлөлтийн үзүүлэх үр нөлөөг мөнгөн гүйлгээний тайланд тусгана. Энэхүү дүнг үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны, санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээнээс тусдаа толилуулах бөгөөд эдгээр мөнгөн гүйлгээг тайлант үеийн эцсийн ханшаар тайлагнаснаар үүсэх аливаа зөрүүг уг дүнд оруулан тусгана.

## Хүү, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт

40. Хүлээн авсан эсвэл төлсөн гэдгээр нь салгаж, хүү, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтаас үүссэн мөнгөн гүйлгээг тус тусад нь толилуулна. Эдгээр мөнгөн гүйлгээ тус бүрийг үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны, санхүүгийн үйл ажиллагааны гэдгээр нэг тайлант үеэс нөгөө тайлант үед тууштай ангилна.
41. Тайлант үеийн туршид төлсөн хүүний нийт дүнг санхүүгийн үр дүнгийн тайланд зардал гэж хүлээн зөвшөөрсөн эсвэл УСНББОУС 5, *Зээлийн Өртөг*-ийн зөвшөөрөгдсөн сонголтот хандлагын дагуу капиталжуулсан эсэхээс үл хамааран мөнгөн гүйлгээний тайланд толилуулна.
42. Төлсөн хүү, хүлээн авсан хүү, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг улсын санхүүгийн байгууллагын хувьд ихэвчлэн үндсэн үйл ажиллагааны

мөнгөн гүйлгээ гэж ангилдаг. Харин бусад байгууллагуудын хувьд эдгээр мөнгөн гүйлгээг хэрхэн ангилах талаар зөвшилцөлд хүрээгүй байна. Төлсөн хүү, хүлээн авсан хүү, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт нь ашиг, алдагдлыг тодорхойлоход ордог тул тэдгээрийг үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ гэж ангилж болох юм. Харин нөгөө талаас, төлсөн хүү, хүлээн авсан хүү, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт нь санхүүгийн эх үүсвэр олж авах өртөг зардал буюу хөрөнгө оруулалтын өгөөж тул санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ ба хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ гэж ангилж болох билээ.

43. Төлсөн ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт нь санхүүгийн эх үүсвэр олж авах өртөг зардал тул түүнийг санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ гэж ангилж болно. Нөгөө талаас, үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээгээр ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг төлөх уг байгууллагын чадвар, боломжийг тодорхойлоход хэрэглэгчдэд туслахын тулд төлсөн ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний бүрэлдэхүүн хэсэг байдлаар ангилж болох юм.

## Орлогын албан татвар

44. **Орлогын албан татвартай холбоотойгоор үүссэн мөнгөн гүйлгээг санхүүгийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ гэж тусгайлан тодорхойлж болохоос бусад тохиолдолд тэдгээрийг тусад нь толилуулж, үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ гэж ангилна.**
45. Улсын секторын байгууллагууд нь ерөнхийдөө орлогын албан татвараас чөлөөлөгддөг. Гэвч улсын секторын зарим байгууллагууд нь татварын ижил зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулж болох бөгөөд энэ тохиолдолд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд хэрэглэдэгтэй ижил арга замаар татварыг ногдуулдаг.
46. Орлогын албан татвар нь мөнгөн гүйлгээг бий болгох ажил гүйлгээнээс үүсдэг. Уг мөнгөн гүйлгээг мөнгөн гүйлгээний тайланд үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны, санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ гэж ангилдаг. Татварын зардлыг хөрөнгө оруулалтын эсвэл санхүүгийн үйл ажиллагаанд шууд хамааруулан тодорхойлж болох хэдий ч холбогдох татварын мөнгөн гүйлгээг ихэвчлэн шууд тодорхойлох практик боломжгүй байдаг бөгөөд тухайн суурь ажил гүйлгээнээс хамааран өөр өөр тайлант үеүдэд үүсэж болох юм. Иймээс төлсөн татварыг ямагт үндсэн үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн гүйлгээ гэж ангилдаг. Харин хөрөнгө оруулалтын эсвэл санхүүгийн үйл ажиллагааны гэж ангилах мөнгөн гүйлгээг үүсгэн бий болгох тийм тодорхой нэг ажил гүйлгээнд хамааруулан уг татварын мөнгөн гүйлгээг тодорхойлох практик боломжтой тохиолдолд тэрхүү татварын мөнгөн гүйлгээг аль тохиромжтой байдлаар хөрөнгө оруулалтын эсвэл санхүүгийн үйл ажиллагааны гэж ангилна. Татварын мөнгөн гүйлгээг

нэгээс олон үйл ажиллагааны ангид хуваарилах тохиолдолд төлсөн татварын нийт дүнгийн талаар тодруулга хийнэ.

### **Хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалт**

47. Хараат байгууллага, хамтарсан үйлдвэр эсвэл хяналтанд буй байгууллага дахь хөрөнгө оруулалтыг өмчийн эсвэл өртгийн арга ашиглан тайлагнадаг тохиолдолд хөрөнгө оруулагч нь санхүүжигчийн болон өөрийнхөө хооронд хийгдсэн мөнгөн гүйлгээг, тухайлбал ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт ба мөнгөн урьдчилгааг мөнгөн гүйлгээний тайланд тайлагнахыг хориглодог.
48. Хараат байгууллага эсвэл хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоогоо өмчийн аргыг ашиглан тайлагнадаг байгууллага нь тэрхүү хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалт, өөрийнхөө болон уг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийн хооронд хийгдсэн хуваарилалт, бусад мөнгөн төлбөр буюу орлоготой холбоотой мөнгөн гүйлгээнүүдийг өөрийн мөнгөн гүйлгээний тайландаа тусган оруулна.

### **Хяналтанд буй байгууллагууд болон үйл ажиллагааны бусад нэгжүүдийн худалдан авалт ба данснаас хасалт**

49. Хяналтанд буй байгууллагууд буюу үйл ажиллагааны бусад нэгжүүдийн худалдан авалт ба данснаас хасалтаас үүссэн нийт мөнгөн гүйлгээг тусад нь толилуулж, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа гэж ангилна.
50. Байгууллага нь хяналтанд буй байгууллагууд буюу үйл ажиллагааны бусад нэгжүүдийн худалдан авалт ба данснаас хасалттай холбоотойгоор тухайн тайлант үеийн туршид гарсан дараах зүйл тус бүрийг нэгдсэн дүнгээр толилуулна:
  - (а) Төлсөн эсвэл хүлээн авсан зүйлийн нийт дүн;
  - (б) Тухайн худалдан авалтын эсвэл данснаас хасалтын төлбөрөөс мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгөөр барагдуулсан хэсэг;
  - (в) Худалдан авсан эсвэл данснаас хассан уг хяналтанд буй байгууллага буюу үйл ажиллагааны нэгжийн мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийн дүн; ба
  - (г) Худалдан авсан эсвэл данснаас хассан уг хяналтанд буй байгууллага буюу үйл ажиллагааны нэгжийн хүлээн зөвшөөрсөн, мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгөөс бусад, хөрөнгө ба өр төлбөрийн гол анги тус бүрээр нэгтгэн товчоолсон дүн.
- 50А. УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*-д тодорхойлсончлон, хөрөнгө оруулалтын байгууллага нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит



## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

үнэ цэнээр хэмжих шаардлагатай хяналтанд буй байгууллага дахь хөрөнгө оруулалтын хувьд 50(в) эсвэл 50(г) параграфыг мөрдөх шаардлагагүй юм. Өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага биш, хяналт тавигч байгууллага нь тухайн хөрөнгө оруулалтыг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг тохиолдолд уг хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллага дахь хөрөнгө оруулалтын хувьд 50(в) эсвэл 50(г) параграфыг мөрдөх шаардлагагүй юм.

51. Хяналтанд буй байгууллагууд болон үйл ажиллагааны бусад нэгжүүдийн худалдан авалт ба данснаас хасалтын мөнгөн гүйлгээний үр нөлөөг тухайн олж авсан буюу данснаас хассан хөрөнгө, өр төлбөрийн тусдаа толилуулгын хамтаар нэг мөрийн зүйл болгон тусдаа толилуулах нь тэдгээр мөнгөн гүйлгээг үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны, санхүүгийн үйл ажиллагааны бусад мөнгөн гүйлгээнээс ялган тодорхойлоход тусалдаг. Данснаас хасалтын мөнгөн гүйлгээний үр нөлөөг худалдан авалтын мөнгөн гүйлгээнээс хасахгүй.
52. Худалдан авалт буюу борлуулалтын төлбөр байдлаар төлсөн эсвэл хүлээн авсан мөнгөний нийт дүнг уг ажил гүйлгээний нэг хэсэг байдлаар олж авсан буюу зарцуулсан мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийг хассан цэвэр дүнгээр мөнгөн гүйлгээний тайланд тайлагнадаг.
- 52A. УСНББОУС 35-д тодорхойлсончлон, хяналтанд буй байгууллагыг хөрөнгө оруулалтын байгууллага эсвэл хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагаар дамжуулан эзэмшдэг бөгөөд түүнийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих шаардлагатайгаас бусад тохиолдолд хяналтаа алдахад хүргэхээргүй, уг хяналтанд буй байгууллага дахь өмчлөлийн хувь оролцооны өөрчлөлтөөс үүссэн мөнгөн гүйлгээг санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ гэж ангилна.
- 52Б. Хяналтанд буй байгууллагыг хөрөнгө оруулалтын байгууллага эсвэл хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагаар дамжуулан эзэмшдэг бөгөөд түүнийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих шаардлагатайгаас бусад тохиолдолд хяналтаа алдахад хүргэхээргүй, уг хяналтанд буй байгууллага дахь өмчлөлийн хувь оролцооны өөрчлөлтийг өмчийн ажил гүйлгээ гэж тайлагнана (УСНББОУС 35-ыг үзнэ үү). Жишээлбэл; хяналт тавигч байгууллага нь уг хяналтанд буй байгууллагын өмчийн хэрэглүүрийг дараа нь худалдан авах эсвэл борлуулах гэх мэт. Иймээс, үүний үр дүн болох мөнгөн гүйлгээг 26-р параграфт дурдсан, бусад ажил гүйлгээтэй ижил арга замаар ангилна.
53. Худалдан авсан эсвэл данснаас хассан хяналтанд буй байгууллага буюу үйл ажиллагааны нэгжийн мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгөөс бусад, хөрөнгө болон өр төлбөрийг тэрхүү хяналтанд буй байгууллага өмнө нь хүлээн зөвшөөрч байсан зөвхөн тийм тохиолдолд тэдгээрийн хувьд тодруулга хийх шаардлагатай. Жишээлбэл; санхүүгийн тайлангаа мөнгөн суурийн дагуу бэлтгэдэг улсын секторын байгууллагыг улсын секторын өөр нэг байгууллага худалдан авсан тохиолдолд тухайн хяналтанд орсон байгууллага нь мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрөө хүлээн зөвшөөрдөггүй

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

байсан тул уг худалдан авсан байгууллага нь түүний хөрөнгө, өр төлбөрийг (мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгөөс бусад) толилуулах шаардлагагүй юм.

### Мөнгөн бус ажил гүйлгээ

54. **Мөнгө буюу мөнгөтэй адилтгах хөрөнгийг ашиглан зарцуулахыг шаардахгүй тийм хөрөнгө оруулалтын болон санхүүгийн ажил гүйлгээг мөнгөн гүйлгээний тайланд тусгахгүй. Ийм ажил гүйлгээг тэдгээр хөрөнгө оруулалтын болон санхүүгийн үйл ажиллагааны талаархи холбогдох бүх мэдээллээр хангах тийм арга замаар санхүүгийн тайлангийн аль нэг хэсэгт толилуулна.**
55. Хөрөнгө оруулалтын болон санхүүгийн олон үйл ажиллагаа нь байгууллагын капитал ба хөрөнгийн бүтцэд нөлөөлдөг боловч тайлант үеийн мөнгөн хөрөнгийн гүйлгээнд шууд нөлөө үзүүлдэггүй. Мөнгөн бус ажил гүйлгээ нь тухайн тайлант үеийн мөнгөн гүйлгээг өөртөө агуулдаггүй тул тэдгээрийг мөнгөн гүйлгээний тайланд оруулахгүй байх нь мөнгөн гүйлгээний тайлангийн зорилготой нийцэх юм. Мөнгөн бус ажил гүйлгээний жишээ нь:
- (а) хөрөнгийг бусад хөрөнгөөр солилцон арилжих, тухайн хөрөнгөтэй шууд холбоотой өр төлбөрийг хариуцах замаар эсвэл санхүүгийн түрээсээр олж эзэмших;
  - (б) өр төлбөрийг өмчид хөрвүүлэх.

### Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгүүд

56. **Байгууллага нь мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгүүдийг толилуулах бөгөөд мөнгөн гүйлгээний тайлан дахь тэдгээрийн дүнг санхүүгийн байдлын тайланд тусгасан тухайн зүйлийн харгалзах дүнтэй тулган тохируулж, толилуулна.**
57. Дэлхий дахин дахь мөнгөнийн менежментийн янз бүрийн практик ажиллагаа ба банкны механизмыг харгалзан үзэх, түүнчлэн УСНББОУС 1-ийг даган мөрдөхийн тулд байгууллага нь мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлоход баримталсан бодлогын хувьд тодруулга хийнэ.
58. Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлох бодлогын аливаа өөрчлөлтийн, жишээлбэл, өмнө нь тухайн байгууллагын хөрөнгө оруулалтын багцын нэг бүрэлдэхүүн хэсэг гэж үздэг байсан санхүүгийн хэрэглүүрийн ангиллын өөрчлөлтийн үр нөлөөг УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого*, *Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-ны дагуу тайлагнана.

## Бусад тодруулга

59. **Байгууллага нь тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын ашиглалт зарцуулалтанд хамаарахгүй бөгөөд өөрийн эзэмшиж буй мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийн томоохон үлдэгдлийн дүнг удирдлагын хийсэн тайлбарын хамт санхүүгийн тайлангийн тодруулга хэсэгт толилуулна.**
60. Байгууллагын эзэмшиж байгаа мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл нь тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын ашиглалт зарцуулалтанд хамаарахгүй байх тийм янз бүрийн нөхцөл байдлууд байдаг. Жишээлбэл; валютын зохицуулалт буюу эрх зүйн бусад хязгаарлалтыг мөрддөг улс оронд үйл ажиллагаагаа явуулдаг, хяналтанд буй байгууллагын эзэмшиж буй мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл нь уг хяналт тавигч байгууллага эсвэл хяналтанд буй бусад байгууллагуудын ерөнхий хэрэгцээнд ашиглан зарцуулагдах боломжгүй байдаг.
61. Байгууллагын санхүүгийн байдал ба төлбөрийн чадварыг ойлгоход хэрэглэгч нарт өөр нэмэлт мэдээлэл хэрэгцээтэй байж болно. Санхүүгийн тайлангийн тодруулга дахь тайлбар тодорхойлолтын хамтаар ийм мэдээллийг толилуулахыг дэмждэг бөгөөд үүнд дараах зүйлс хамаарч болно:
- (а) Ирээдүйн үйл ажиллагаанд болон капиталын хариуцлагыг биелүүлэхэд ашиглагдах боломжтой ашиглагдаагүй зээлийн эх үүсвэрийн дүн, мөн тэдгээр эх үүсвэрийн ашиглалтанд тавигдах аливаа хязгаарлалтуудыг илэрхийлэх;
  - (б) [Хассан]
  - (в) Хязгаарласан мөнгөний үлдэгдлийн дүн ба шинж төрөл.
62. Төсвийн хуваарилалт буюу төсвийн эрхийг мөнгөн сууриар бэлтгэдэг тохиолдолд мөнгөн гүйлгээний тайлан нь тухайн байгууллагын үйл ажиллагаа, хөтөлбөр ба засгийн газрын төсвийн мэдээллийн хоорондох харилцан хамаарлыг ойлгоход хэрэглэгчдэд туслалцаа үзүүлж болох юм. Гүйцэтгэл ба төсөвлөсөн дүнгийн харьцуулалтын талаархи товч хэлэлцүүлгийг УСНББОУС 1-ээс үзнэ үү.

## Хүчин төгөлдөр болох хугацаа

63. **Байгууллага нь энэхүү Стандартыг 2001 оны 7 дугаар сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2001 оны 7 дугаар сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.**

- 63А. 2010 оны 01 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Сайжруулалтууд*-аар 22-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2011 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2011 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх ба УСНББОУС 17-гийн 83А параграфыг мөрдөнө.
- 63Б. 2010 оны 11 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Сайжруулалтууд*-аар 25-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2012 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2012 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 63В. 2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-ийн үр дүнд 64-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед УСНББОУС 33-ыг мөрдсөн бол уг нэмэлт өөрчлөлтийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.
- 63Г. 2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан* ба УСНББОУС 37, *Хамтын Хэлэлцээр*-ийн үр дүнд 8, 30(б), 47, 48, 61(б) параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулж, 50А, 52А, 52Б параграфуудыг шинээр нэмсэн. Байгууллага нь УСНББОУС 35 ба УСНББОУС 37-г мөрдсөн үеэс эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг дагаж мөрдөнө.
- 63Д. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 3, 4, 16-р параграфуудыг хассан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
64. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш,

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

## Дүгнэлтийн Үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 2-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### **2009 онд гаргасан, НББОУС3-ийн СТОУС-ын Сайжруулалтууд-ын үр дүнд УСНББОУС 2-д хийсэн хянан засварлалт**

ДҮ1. УСНББОУС3 нь 2009 оны 4 дүгээр сард НББОУС3-өөс гаргасан СТОУС-ын Сайжруулалтууд-д тусгасан, НББОУС 7-гийн хянан засварлалтыг нягталж шалгаад уг Стандартыг хянан засварлах болсон НББОУС3-ийн учир шалтгаантай ерөнхийдөө санал нийлсэн. УСНББОУС3 нь уг нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдөхгүй байх улсын секторын тусгай учир шалтгаан байхгүй гэж дүгнэсэн.

### **2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУС3-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 2-д хийсэн хянан засварлалт**

ДҮ2. УСНББОУС3 нь 2016 оны 4 дүгээр сард УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (а) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р параграфт* нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

## Үлгэрчилсэн жишээ

Энэхүү жишээ нь УСНББОУС 2-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

### Мөнгөн гүйлгээний тайлан (Санхүүгийн байгууллагаас бусад, байгууллагад зориулав)

Шууд аргаар бэлтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (27(а) параграф)

### Улсын секторын байгууллага - 20Х2 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жилийн Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

	(мянгачилсан дүнгээр) 20Х2	20Х1
<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>Мөнгөн орлого</b>		
Татвар	X	X
Бараа, үйлчилгээний борлуулалт	X	X
Буцалтгүй тусламж	X	X
Хүлээн авсан хүү	X	X
Бусад орлого	X	X
<b>Мөнгөн төлбөр</b>		
Ажиллагчдын зардал	(X)	(X)
Тэтгэвэр, тэтгэмжийн хөтөлбөр	(X)	(X)
Бэлтгэн нийлүүлэгчдийн төлбөр	(X)	(X)
Төлсөн хүү	(X)	(X)
Бусад төлбөр	(X)	(X)
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<u>X</u>	<u>X</u>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	(X)	(X)
Үндсэн хөрөнгийн борлуулалтын мөнгөн орлого	X	X
Хөрөнгө оруулалтын борлуулалтын мөнгөн орлого	X	X
Гадаад валютаар худалдан авсан үнэт цаас	(X)	(X)
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<u>(X)</u>	<u>(X)</u>
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
Авсан зээл	X	X
Зээлийн буцаан төлөлт	(X)	(X)
Засгийн газарт олгосон хуваарилалт/ногдол ашиг	(X)	(X)
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<u>X</u>	<u>X</u>
<b>Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/(бууралт)</b>	X	X
<b>Тайлант үеийн эхэн дэх мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө</b>	<u>X</u>	<u>X</u>
<b>Тайлант үеийн эцэс дэх мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө</b>	<u><u>X</u></u>	<u><u>X</u></u>

## Мөнгөн гүйлгээний тайлангийн тодруулга

(a) *Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө*

Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө нь бэлэн мөнгө, банкин дахь мөнгө, мөнгөний зах зээлийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтаас бүрддэг. Мөнгөн гүйлгээний тайланд тусгасан мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө нь санхүүгийн байдлын тайлангийн дараах дүнгүүдээс бүрдэнэ:

(мянгачилсан дүнгээр)	20X2	20X1
Бэлэн мөнгө ба банкин дахь мөнгө	X	X
Богино хугацаат хөрөнгө оруулалт	X	X
	<b>X</b>	<b>X</b>

Уг байгууллага нь X хэмжээний ашиглаагүй зээлийн хэрэгсэлтэй бөгөөд үүнээс X хэмжээний зээлийг дэд бүтцийн төслүүдэд зарцуулах ёстой.

(б) *Үндсэн хөрөнгө*

Тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллага нь тайлант үеийн туршид X хэмжээний нийт өртөгтэй үндсэн хөрөнгийг олж эзэмшсэн бөгөөд үүнээс X хэмжээний үндсэн хөрөнгийг үндэсний засгийн газрын капитал буцалтгүй тусламжаар олж авсан. Үндсэн хөрөнгийг худалдан авахын тулд X хэмжээний мөнгө төлсөн.

(в) *Үндсэн үйл ажиллагааны Цэвэр мөнгөн гүйлгээг Ашиг/(алдагдал)-тай тохируулах*

(мянгачилсан дүнгээр)	20X2	20X1
<b>Ашиг/(алдагдал)</b>	<b>X</b>	<b>X</b>
<b>Мөнгөн бус өөрчлөлтүүд</b>		
Элэгдэл	X	X
Хорогдуулга	X	X
Найдваргүй авлагын нөөцийн өсөлт	X	X
Өглөгийн өсөлт	X	X
Зээлийн өсөлт	X	X
Ажиллагчдын зардалтай холбоотой нөөцийн өсөлт	X	X
Үндсэн хөрөнгийн борлуулалтын (олз)/гарз	(X)	(X)
Хөрөнгө оруулалтын борлуулалтын (олз)/гарз	(X)	(X)
Бусад эргэлтийн хөрөнгийн өсөлт	(X)	(X)
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт	(X)	(X)
Авлагын өсөлт	(X)	(X)
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>X</b>	<b>X</b>



МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Шууд аргаар бэлтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (27(б) параграф)

**Улсын секторын байгууллага - 20Х2 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жилийн Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**

(мянгачилсан дүнгээр)	20Х2	20Х1
<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
Ашиг/(алдагдал)	X	X
<b>Мөнгөн бус өөрчлөлтүүд</b>		
Элэгдэл	X	X
Хорогдуулга	X	X
Найдваргүй авлагын нөөцийн өсөлт	X	X
Өглөгийн өсөлт	X	X
Зээлийн өсөлт	X	X
Ажиллагчдын зардалтай холбоотой нөөцийн өсөлт	X	X
Үндсэн хөрөнгийн борлуулалтын (олз)/гарз	(X)	(X)
Хөрөнгө оруулалтын борлуулалтын (олз)/гарз	(X)	(X)
Бусад эргэлтийн хөрөнгийн өсөлт	(X)	(X)
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт	(X)	(X)
Авлагын өсөлт	(X)	(X)
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>X</b>	<b>X</b>

**Мөнгөн гүйлгээний тайлангийн тодруулга**

(а) *Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө*

Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө нь бэлэн мөнгө, банкин дахь мөнгө, мөнгөний зах зээлийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтаас бүрддэг. Мөнгөн гүйлгээний тайланд тусгасан мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө нь санхүүгийн байдлын тайлангийн дараах дүнгүүдээс бүрдэнэ:

(мянгачилсан дүнгээр)	20Х2	20Х1
Бэлэн мөнгө ба банкин дахь мөнгө	X	X
Богино хугацаат хөрөнгө оруулалт	X	X
	<b>X</b>	<b>X</b>

Уг байгууллага нь Х хэмжээний ашиглаагүй зээлийн хэрэгсэлтэй бөгөөд үүнээс Х хэмжээний зээлийг дэд бүтцийн төслүүдэд зарцуулах ёстой.

(б) *Үндсэн хөрөнгө*

Тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллага нь тайлант үеийн туршид Х хэмжээний нийт өртөгтэй үндсэн хөрөнгийг олж эзэмшсэн бөгөөд үүнээс Х хэмжээний үндсэн хөрөнгийг үндэсний засгийн газрын капиталын буцалтгүй тусламжаар олж авсан. Үндсэн хөрөнгийг худалдан авахын тулд Х хэмжээний мөнгө төлсөн.

## НББОУС 7-ТОЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 2, *Мөнгөн Гүйлгээний Тайлан*-г НББОУС 7, *Мөнгөн Гүйлгээний Тайлан*-гаас үндсэндээ бэлтгэсэн бөгөөд 2009 оны 4 дүгээр сард гаргасан, *СТОУС-ын Сайжруулалтууд*-ын нэг хэсэг байдлаар НББОУС 7-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг үүнд тусгасан болно. УСНББОУС 2 ба НББОУС 7-гийн хоорондох гол зөрүү нь дараах байдалтай байна:

- УСНББОУС 2 нь зарим тохиолдолд НББОУС 7-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь УСНББОУС 2 дох “санхүүгийн үр дүнгийн тайлан” ба “цэвэр хөрөнгө/өмч” гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. НББОУС 7 дох адилтгах нэр томъёо нь “орлогын тайлан” ба “өмч” юм.
- УСНББОУС 2 нь НББОУС 7 (8-р параграф)-д зааснаас өөр, техникийн нэр томъёоны цогц тодорхойлолтыг агуулсан байдаг.
- НББОУС 7-той нийтлэг зүйл нь үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг толилуулахдаа шууд буюу шууд бус аргын аль нэгийг ашиглахыг УСНББОУС 2-оор зөвшөөрдөг явдал юм. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг толилуулахын тулд шууд аргыг ашигладаг тохиолдолд ашиг, алдагдлыг үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээтэй уялдуулах тохируулгыг санхүүгийн тайлангийн тодруулгад тусгахыг УСНББОУС 2-оор дэмжин зөвшөөрдөг (29-р параграф).
- УСНББОУС 2-ыг дагалдах, Үлгэрчилсэн жишээнд санхүүгийн байгууллагын Мөнгөн гүйлгээний тайлангийн үлгэрчилсэн жишээг тусгаагүй болно.

## УСНББОУС 3-НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТООЦООЛЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА АЛДАА

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) 8, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* (2003 онд хянан засварласан)-наас үндсэндээ бэлтгэсэн болно. НББОУС 8-аас авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон EC4M 6XH, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)

Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.

**УСНББОУС 3-НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, НЯГТЛАН БОДОХ  
БҮРТГЭЛИЙН ТООЦООЛЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА АЛДАА**

**УСНББОУС-ын түүх**

Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

УСНББОУС 3, Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа-г 2000 оны 5 дугаар сард гаргасан.

2006 оны 12 дугаар сард УСНББОУС3 нь хянан засварласан УСНББОУС 3-ыг гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 3-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2011-ийн Сайжруулалтууд (2011 оны 10 дугаар сард гаргасан)
- УСНББОУС-ын Сайжруулалтууд (2010 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 31, Биет Бус Хөрөнгө (2010 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС-ын Сайжруулалтууд (2010 оны 11 дүгээр сард гаргасан)

**УСНББОУС 3-ын нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт**

Өөрчлөгдсөн параграф	Хэрхэн өөрчилсөн	Юугаар өөрчилсөн
Танилцуулга хэсэг	Хассан	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
Танилцуулга 11-ийн дээд талын гарчиг	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
5	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
6	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
7	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
9	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН  
 ТООЦООЛЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА АЛДАА

10	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
11	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар
12	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
13	Хассан	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
14	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
15	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
17	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
22	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 31, 2010 оны 01-р сар
34	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
59А	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар
59Б	Шинэ	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
59В	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
59Г	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
60	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар

2006 оны 12 дугаар сар

**УСНББОУС 3–НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО,  
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТООЦООЛЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА  
АЛДАА**

**АГУУЛГА**

	Параграф
Зорилго	1-2
Цар хүрээ	3-6
Тодорхойлолт	7-8
Материаллаг байдал	8
Нягтлан бодох бүртгэлийн бодлого	9-36
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын сонголт ба мөрдөлт	9-15
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын тууштай байдал	16
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	17-36
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг мөрдөх	24-32
Буцаах горимоор мөрдөлт	27
Буцаах горимоор мөрдөлтийн хязгаарлагдмал талууд	28-32
Тодруулга	33-36
Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт	37-45
Тодруулга	44-45
Алдаа	46-54
Буцаан дахин тайлагналтын хязгаарлагдмал талууд	48-53
Өмнөх тайлант үеийн алдааны тодруулга	54
Буцаах горимоор мөрдөлт ба буцаан дахин тайлагналтын практик боломжгүй байдал	55-58
Хүчин төгөлдөр болох хугацаа	59-60
УСНББОУС 3 (2000)-аас татгалзах	61
Хавсралт: Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт	
Дүгнэлтийн үндэслэл	
Хэрэгжүүлэх заавар удирдамж	
НББОУС 8-тай харьцуулалт	

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН  
ТООЦООЛЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА АЛДАА

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-г 1-61-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 3-ыг түүний зорилгын агуулга, Дүгнэлтийн Үндэслэл, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

1. Энэхүү Стандартын зорилго нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба өөрчлөх шалгуурыг (а) нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн, (б) нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтийн, (в) алдааны залруулгын нягтлан бодох бүртгэлийн арга хандлага болон тодруулгын хамтаар тодорхойлоход оршино. Энэ Стандарт нь байгууллагын санхүүгийн тайлангийн хамааралтай ба үнэн зөв илэрхийлэлт, түүнчлэн санхүүгийн тайланг тайлант үеүдийн хооронд болон бусад байгууллагуудын санхүүгийн тайлантай зэрэгцүүлэх боломжтой байдлыг нэмэгдүүлэхэд чиглэгддэг.
2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөс бусад, нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулгын шаардлагуудыг УСНББОУС 1, *Санхүүгийн Тайлангийн Топилуулга*-д заасан байдаг.

## Цар хүрээ

3. **Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт, өмнөх тайлант үеүдийн алдааны залруулгыг бүртгэхдээ энэхүү Стандартыг мөрдөнө.**
4. Өмнөх тайлант үеийн алдааны засварлалт ба нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг даган мөрдөхийн тулд буцаах горимоор хийсэн тохируулгын татварын үр нөлөө нь улсын секторын олон байгууллагуудын хувьд хамааралгүй тул түүнийг энэхүү Стандартад авч үзээгүй. Орлогын албан татварыг зохицуулах олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн стандартууд нь татварын үр нөлөөг тайлагнах талаархи заавар удирдамжийг агуулсан байдаг.
5. [Хассан]
6. [Хассан]

## Тодорхойлолт

7. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

**Нягтлан бодох бүртгэлийн бодлого** гэдэг нь санхүүгийн тайланг бэлтгэж, толилуулахдаа байгууллагын мөрддөг тусгай зарчим, суурь, дүрэм, журам, тогтсон практик юм.

**Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт** гэдэг нь хөрөнгө, өр төлбөрийн одоогийн төлөв байдлын, түүнчлэн хөрөнгө, өр төлбөртэй холбоотойгоор хүлээгдэж буй ирээдүйн өгөөж, үүргийн талаархи үнэлгээний үр дүнд тухайн хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд эсвэл хөрөнгийн үечилсэн хэрэглээ зарцуулалтын дүнд хийх



тохируулга юм. Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт нь шинэ мэдээлэл буюу шинэ хөгжил дэвшлээс бий болдог, иймээс алдааны залруулга биш юм.

**Практик боломжгүй** - тухайн байгууллага нь боломжит бүх хүчин чармайлтыг гаргасан боловч даган мөрдөж чадахгүй тохиолдолд уг шаардлагыг даган мөрдөх практик боломжгүй байна. Доорх тохиолдолд өмнөх тодорхой нэг тайлант үеийн хувьд нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг буцаах горимоор мөрдөх эсвэл алдааг засварлахын тулд буцаан дахин тайлагнах практик боломжгүй байдаг:

- (a) Буцаах горимоор мөрдөлт буюу буцаан дахин тайлагналтын үр нөлөөг тодорхойлох боломжгүй;
- (б) Буцаах горимоор мөрдөлт буюу буцаан дахин тайлагналт нь тэрхүү тайлант үед удирдлагын санаа зорилго ямар байсан талаархи таамаглал хийхийг шаарддаг; эсвэл
- (в) Буцаах горимоор мөрдөлт буюу буцаан дахин тайлагналт нь дүнгүүдийн нилээд нүсэр тооцооллыг шаарддаг бөгөөд доорх тооцооллуудын талаархи мэдээллийг бодитойгоор салган зааглах боломжгүй байх:
  - (i) дүнгүүдийг хүлээн зөвшөөрөх, хэмжих буюу тодруулах үед оршин байсан нөхцөл байдлын тухай нотолгоогоор хангах тооцоолол;
  - (ii) тэрхүү өмнөх тайлант үеийн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрөх үед бусад мэдээллээс тооцон гаргаж, бэлэн байлгаж болох байсан тийм тооцоолол.

**Өмнөх тайлант үеийн алдаа** гэдэг нь үнэн зөв илэрхийлэх дараах мэдээллийг ашиглаагүй эсвэл буруу ашигласны улмаас тухайн байгууллагын нэг буюу хэд хэдэн тайлант үеүдийн санхүүгийн тайланд эдгээр мэдээллийг тусгахгүй орхигдуулалт болон буруу тусган илэрхийлэлт юм:

- (a) эдгээр тайлант үеүдийн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрөх үед бэлэн боломжтой байсан;
- (б) эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх болон толилуулах явцад олж авах ба түүнд харгалзан тусган оруулна гэж ул үндэслэлтэйгээр хүлээгдэж болох.

Ийм алдаанд математик үйлдлийн алдаа, нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдөхөд гаргасан алдаа, бодит байдалд хайнга хандалт буюу түүнийг буруу тайлбарлалт, түүнчлэн зальт ажиллагааны үр нөлөө хамаардаг.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг, түүнчлэн нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтийн үр нөлөөг тус тус

**Гүйцээх горимоор мөрдөлт** гэдэг нь харгалзан дараах зүйлсийг хэлнэ:

- (а) тухайн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчилсөн өдрөөс хойш гарч тохиолдсон ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдалд уг шинэ бодлогыг мөрдөхийг;
- (б) нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтийн үр нөлөөг уг өөрчлөлтөөр нөлөө үзүүлэх тухайн тайлант үед болон ирээдүйн тайлант үеүдэд хүлээн зөвшөөрөхийг.

**Буцаах горимоор мөрдөлт** гэдэг нь нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг угаасаа мөрдөж байсан бол ямар байх байсан тийм байдлаар ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдалд тэрхүү бодлогыг даган мөрдөхийг хэлнэ.

**Буцаан дахин тайлагналт** гэдэг нь өмнөх тайлант үеийн алдаа угаасаа гараагүй бол ямар байх байсан тийм байдлаар санхүүгийн тайлангийн элементүүдийн дүнгийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, тодруулгыг засварлахыг хэлнэ.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д дахин нийтэлсэн болно.

### **Материаллаг байдал**

8. Орхигдуулалт эсвэл буруу тайлагналт нь хэрэглэгчдийн шийдвэрт нөлөөлөх, ингэснээр материаллаг болох эсэхийг үнэлэхдээ тэдгээр хэрэглэгчдийн шинж чанарыг харгалзан үзэх шаардлагатай байдаг. Хэрэглэгчид нь улсын сектор, эдийн засгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн талаар зохих мэдлэгтэй бөгөөд тэд мэдээллийг ул үндэслэлтэй хянамгай байдлаар судлан мэдэх хүсэл эрмэлзэлтэй байдаг гэж үзнэ. Тиймээс, ийм төлөв шинж бүхий хэрэглэгчдийн шийдвэр гаргалт ба үнэлгээнд хэрхэн нөлөө үзүүлэхээр ул үндэслэлтэйгээр хүлээгдэж болохыг уг үнэлэлтэнд харгалзан үзэх шаардлагатай.

### **Нягтлан бодох бүртгэлийн бодлого**

#### **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын сонголт ба мөрдөлт**

9. **Аль нэг УСНББОУС-ыг ажил гүйлгээ, бусад үйл явдал буюу нөхцөл байдалд тусгайлан мөрддөг тохиолдолд тэдгээрт мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого буюу бодлогуудыг уг УСНББОУС-ын дагуу тодорхойлно.**
10. Тухайн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдөх ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын талаар хамааралтай ба үнэн зөв илэрхийлэх мэдээллийг агуулсан санхүүгийн тайланг бэлтгэхэд хүргэнэ гэж УСНББОУС3-өөс дүгнэсэн тийм нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН  
ТООЦООЛЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА АЛДАА

УСНББОУС-д тодорхойлж заадаг. Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдсөний үр нөлөө нь материаллаг бус тохиолдолд тэдгээр бодлогыг мөрдөхийг шаарддаггүй. Гэвч байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тухайлсан нэг толилуулгад хүрэхийн тулд УСНББОУС-аас материаллаг бус байдлаар гажуудуулах эсвэл тийм гажилтыг засварлахгүй орхих нь зохисгүй юм.

11. УСНББОУС-ын шаардлагуудыг даган мөрдөхөд нь байгууллагуудад туслах тийм заавар удирдамжийг УСНББОУС-ууд агуулсан байдаг. Эдгээр нь УСНББОУС-ын салшгүй хэсэг мөн эсэхийг ийм бүх заавар удирдамжинд илэрхийлсэн байдаг. УСНББОУС-ын салшгүй хэсэг болох заавар удирдамжийг заавал дагаж мөрдөнө. Харин УСНББОУС-ын салшгүй хэсэг болохгүй тийм заавар удирдамж нь санхүүгийн тайланд хамаарах шаардлагуудыг өөртөө агуулаагүй байдаг.
12. **Ажил гүйлгээ, бусад үйл явдал буюу нөхцөл байдалд тусгайлан мөрдөх УСНББОУС байхгүй тохиолдолд удирдлага нь дараах шинж, нөхцөл бүхий мэдээллийг бий болгоход хүргэх нягтлан бодох бүртгэлийн бодлогыг боловсруулж, мөрдөхдөө өөрийн шүүн тунгаалтыг хийнэ. Мэдээлэл нь хэрэглэгчдийн тайлагнах ба шийдвэр гаргах хэрэгцээ шаардлагад хамааралтай; тухайн байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлэх; ба ойлгомжтой байх, цаг хугацаандаа байх, зэрэгцүүлэгдэх боломжтой байх, шалгах боломжтой байх гэсэн чанарын шинжүүдийг хангах; нийтлэг зорилготой санхүүгийн тайланд тусгасан мэдээллийн хязгаарлагдмал талууд, түүнчлэн чанарын шинжүүдийн хоорондох тэнцвэрийг харгалзсан байна.**
13. [Хассан]
14. 12-р параграфт дурдсан шүүн тунгаалтыг хийхдээ удирдлага нь дараах дарааллаар илэрхийлсэн эх сурвалжуудыг мөрдөх боломжтой байдлыг авч үзэж, харгалзвал зохино:
  - (а) ижил төсөөтэй ба холбоотой асуудлуудын талаархи УСНББОУС-ын шаардлагууд; ба
  - (б) *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал*-д заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт, хүлээн зөвшөөрөлт, хэмжилтийн шалгуур.
15. 12-р параграфт дурдсан шүүн тунгаалтыг хийхдээ удирдлага нь (а) стандарт-тогтоох бусад байгууллагуудын хамгийн сүүлийн үеийн тунхаглалууд, (б) улсын буюу хувийн секторын зөвшөөрөгдсөн практикыг, хэрэв 14-р параграфт дурдсан эх сурвалжтай зөрчилдөхөөргүй бол мөн харгалзан үзэж болох юм. Ийм тунхаглалуудын жишээнд НББОУСЗ-ийн тунхаглалууд, үүн дотроо СТОУС, НББОУСЗ-ийн СТОУС-ын Тайлбарын Хороо (СТОУТХ) буюу

**өмнөх Тайлбарын Байнгын Хороо (ТБХ)-ноос гаргасан Тайлбарууд хамаарна.**

**Нягтлан бодох бүртгэлийн бодлогын тууштай байдал**

16. **УСНББОУС нь нягтлан бодох бүртгэлийн өөр өөр бодлого тохиромжтой байж болох тийм ангилал хийхийг тухайн зүйлийн хувьд тусгайлан шаардсан буюу зааснаас бусад тохиолдолд байгууллага нь ижил төсөөтэй ажил гүйлгээ, бусад үйл явдал болон нөхцөл байдалд түүний нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгож, тууштай мөрдөх хэрэгтэй. Хэрэв УСНББОУС нь ийм ангилал хийхийг шаардсан буюу зөвшөөрсөн бол тэдгээр ангилал тус бүрийн хувьд тохирох нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгож, тууштай мөрдөнө.**

**Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт**

17. **Байгууллага нь зөвхөн дараах тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчилнө. Үүнд:**
- (а) **өөрчлөлтийг УСНББОУС-аар шаардсан; эсвэл**
  - (б) **өөрчлөлт нь тухайн байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээнд ажил гүйлгээ, бусад үйл явдал болон нөхцөл байдлын үзүүлэх үр нөлөөний талаар үнэн зөв илэрхийлэх ба илүү хамааралтай мэдээллээр хангах үр дүнг санхүүгийн тайланд бий болгох.**
18. Санхүүгийн тайлангийн хэрэглэгчид нь санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний хандлагыг тогтоохын тулд тухайн байгууллагын санхүүгийн тайланг тайлант үеүдийн хооронд зэрэгцүүлэх боломжтой байх шаардлагатай. Иймээс нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт нь 17-р параграфт заасан шалгуурын аль нэгийг хангаагүй л бол тухайн нэг ижил нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тайлант үе бүрийн хамрах хугацааны дотор, түүнчлэн нэг тайлант үеэс дараагийн тайлант үед тууштай мөрдөнө.
19. **Нягтлан бодох бүртгэлийн нэг суурийг нягтлан бодох бүртгэлийн өөр нэг сууриар солих өөрчлөлт нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт юм.**
20. **Ажил гүйлгээ, үйл явдал буюу нөхцөл байдлын нягтлан бодох бүртгэлийн хандлага, хүлээн зөвшөөрөлт, хэмжилтийг нягтлан бодох бүртгэлийн нэг суурийн хүрээнд өөрчлөх өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт гэж үзнэ.**
21. **Дараах тохиолдлууд нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт биш юм:**
- (а) **өмнө нь гарч тохиолдож байсан ажил гүйлгээ, бусад үйл явдал буюу нөхцөл байдлаас мөн чанарын хувьд ялгаатай тийм ажил**

гүйлгээ, бусад үйл явдал буюу нөхцөл байдлын хувьд нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдөлт; ба

- (б) өмнө нь гарч тохиолдож байгаагүй, эсвэл гарч тохиолдсон боловч материаллаг бус байсан тийм ажил гүйлгээ, бусад үйл явдал буюу нөхцөл байдлын хувьд нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг мөрдөлт.

22. **УСНББОУС 17, Үндсэн Хөрөнгө эсвэл УСНББОУС 31, Биет бус Хөрөнгө-ийн дагуу хөрөнгийг дахин үнэлэх тийм бодлогыг анх мөрдөх нь энэхүү Стандартад заасан үндэслэлээр биш, харин УСНББОУС 17 эсвэл УСНББОУС 31-д заасны дагуу дахин үнэлгээ гэж үзэх тийм нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт юм.**
23. 22-р параграфт дурдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн хувьд 24-36-р параграфуудыг даган мөрдөхгүй.

*Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг мөрдөх*

24. **28-р параграфт зааснаас бусад тохиолдолд:**

- (а) Байгууллага нь УСНББОУС-ыг анх удаа мөрдсөний үр дүн болох нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг хэрэв уг Стандартад шилжилтийн тусгай нөхцлийг заасан бол түүний дагуу тайлагнана.
- (б) Байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн хувьд мөрдөх шилжилтийн тусгай нөхцөлгүй тийм УСНББОУС-ыг анх удаа мөрдсөнөөр нягтлан бодох бүртгэлийн бодлогоо өөрчилсөн эсвэл нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрөө сайн дураараа өөрчилсөн бол уг өөрчлөлтийг буцаах горимоор мөрдөнө.

25. Энэхүү Стандартын зорилгоор, Стандартыг дурдсан хугацаанаас өмнө дагаж мөрдөлт нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын сайн дураараа өөрчлөлт биш юм.
26. Ажил гүйлгээ, бусад үйл явдал буюу нөхцөл байдалд тухайлан мөрдөх УСНББОУС байхгүй тохиолдолд 15-р параграфт заасны дагуу удирдлага нь (а) стандарт-тогтоох бусад байгууллагуудын хамгийн сүүлийн үеийн тунхаглалууд, (б) улсын буюу хувийн секторын зөвшөөрөгдсөн практикаар тогтоосон нягтлан бодох бүртгэлийн бодлогыг, хэрэв 15-р параграфт дурдсан эх сурвалжтай зөрчилдөхөөргүй бол даган мөрдөж болох юм. Ийм тунхаглалуудын жишээнд НББОУСЗ-ийн тунхаглалууд, үүн дотроо *Санхүүгийн Тайланг Бэлтгэх ба Толилуулах Үзэл Баримтлал*, СТОУС, СТОУТХ буюу өмнөх ТБХ-ноос гаргасан Тайлбарууд хамаарна. Хэрэв ийм тунхаглалын нэмэлт өөрчлөлтийн дараа уг байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн бодлогоо өөрчлөх сонголт хийсэн бол тэрхүү өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн бодлогын сайн дураараа өөрчлөлт байдлаар бүртгэж, тодруулна.

**Буцаах горимоор мөрдөлт**

27. 28-р параграфт зааснаас бусад тохиолдолд, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг 24(а) эсвэл (б) параграфын дагуу буцаах горимоор мөрдсөн бол тухайн байгууллага нь толилуулсан хамгийн эхний өмнөх тайлант үеийн цэвэр хөрөнгө/өмчийн тэдгээр нөлөөлөгдсөн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн эхний үлдэгдлүүд ба түүнээс хойшхи өмнөх тайлант үе бүрд толилуулсан бусад зэрэгцүүлэгдэх дүнгүүдийг уг нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг угаасаа мөрдөж байсан бол ямар байх байсан тийм байдлаар тохируулна.

**Буцаах горимоор мөрдөлтийн хязгаарлагдмал талууд**

28. Буцаах горимоор мөрдөхийг 24(а) эсвэл (б) параграфтаар шаардсан тохиолдолд уг өөрчлөлтийн тодорхой нэг тайлант үед үзүүлэх үр нөлөөг эсвэл нийт хуримтлагдсан үр нөлөөг тодорхойлох практик боломжгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг буцаах горимоор мөрдөнө.
29. Нэг буюу хэд хэдэн өмнөх тайлант үеүүдэд толилуулсан зэрэгцүүлэгдэх мэдээлэлд нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн үзүүлэх тодорхой нэг тайлант үеийн үр нөлөөг тодорхойлох практик боломжгүй тохиолдолд байгууллага нь буцаах горимоор мөрдөх практик боломжтой хамгийн эхний өмнөх тайлант үеийн, магадгүй тухайн тайлант үеийн эхнээс уг нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд мөрдөх бөгөөд тэрхүү тайлант үеийн цэвэр хөрөнгө/өмчийн нөлөөлөгдсөн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн эхний үлдэгдэлд харгалзах тохируулгыг хийнэ.
30. Нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг өмнөх бүх тайлант үеүүдэд мөрдөхийн нийт хуримтлагдсан үр нөлөөг тухайн тайлант үеийн эхний байдлаар тодорхойлох практик боломжгүй тохиолдолд байгууллага нь практик боломжтой хамгийн эхний өмнөх тайлант үеэс эхлэн уг нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг гүйцээх горимоор мөрдөхийн тулд тэдгээр зэрэгцүүлэгдэх мэдээллийг тохируулна.
31. Нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг буцаах горимоор мөрдөх тохиолдолд байгууллага нь буцаах практик боломжтой аль болох олон, өмнөх тайлант үеүдийн зэрэгцүүлэгдэх мэдээллийн хувьд уг нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг мөрдөнө. Өмнөх тодорхой нэг тайлант үеийн санхүүгийн байдлын тайлан дахь эхний ба эцсийн үлдэгдлийн хоёулангийн дүнд үзүүлэх хуримтлагдсан үр нөлөөг нь тодорхойлох практик боломжтой биш л бол уг өмнөх тайлант үе рүү буцаах горимоор мөрдөх практик боломжгүй гэсэн үг юм. Санхүүгийн тайланд толилуулсан тэдгээр өмнөх тайлант үеүүдээс урд өмнөх тайлант үеүдтэй холбоотойгоор хийх тохируулгын дүнг тухайн толилуулсан хамгийн эхний өмнөх тайлант үеийн цэвэр хөрөнгө/өмчийн нөлөөлөгдсөн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН  
ТООЦООЛЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА АЛДАА

эхний үлдэгдэлд тусгана. Ийм тохируулгыг ихэвчлэн хуримтлагдсан ашиг, алдагдалд хийдэг. Гэхдээ цэвэр хөрөнгө/өмчийн бусад бүрэлдэхүүн хэсгүүдэд (тухайлбал, УСНББОУС-д нийцүүлэхийн тулд) энэхүү тохируулгыг хийж болох юм. Түүхэн санхүүгийн мэдээний тойм гэх мэт өмнөх тайлант үеүдийн талаархи аливаа бусад мэдээллийг практик боломжтой аль болох олон тайлант үеүдэд бас буцаан тохируулна.

32. Нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг мөрдсөнөөр өмнөх бүх тайлант үеүдэд үзүүлэх нийт хуримтлагдсан үр нөлөөг тодорхойлж чадахгүйн улмаас байгууллага нь уг шинэ бодлогыг буцаах горимоор мөрдөх практик боломжгүй тохиолдолд 30-р параграфт заасны дагуу практик боломжтой хамгийн эхний өмнөх тайлант үеэс эхлэн тэрхүү шинэ бодлогыг гүйцээх горимоор мөрдөнө. Ингэснээр хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчид хийгдэх нийт хуримтлагдсан тохируулгын тэрхүү мөрдөж эхэлсэн тайлант үеэс урд өмнөх хугацаанд хамаарах хэсгийг харгалзан үздэггүй. Нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг аливаа өмнөх тайлант үеэс эхлэн гүйцээх горимоор мөрдөх практик боломжгүй байлаа ч гэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогоо өөрчлөхийг зөвшөөрдөг. Нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг нэг буюу хэд хэдэн өмнөх тайлант үеүдэд мөрдөх практик боломжгүй тохиолдлын талаархи заавар удирдамжийг 55-58-р параграфт тусгасан.

*Тодруулга*

33. **Аль нэг УСНББОУС-ыг анх удаа мөрдөлт нь (а) тухайн тайлант үед буюу өмнөх аливаа нэг тайлант үед нөлөө үзүүлдэг, (б) тохируулгын дүнг тодорхойлох практик боломжгүйгээс бусад тохиолдолд ийм нөлөө үзүүлэхээр байсан, эсвэл (в) ирээдүйн тайлант үеүдэд нөлөө үзүүлж болохоор байвал байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:**
- (а) **Стандартын нэр;**
  - (б) **Хэрэв тохиромжтой бол стандартын шилжилтийн нөхцлийн дагуу хийсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт;**
  - (в) **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн шинж төрөл;**
  - (г) **Хэрэв тохиромжтой бол тухайн шилжилтийн нөхцлийн тайлбар тодорхойлолт;**
  - (д) **Хэрэв тохиромжтой бол ирээдүйн тайлант үеүдэд нөлөө үзүүлж болох шилжилтийн нөхцлүүд;**
  - (е) **Толилуулсан тухайн тайлант үе болон өмнөх тайлант үе тус бүрд хэрэв практик боломжтой бол уг нөлөөлсөн санхүүгийн тайлангийн мөрийн зүйл тус бүрд хийсэн тохируулгын дүн;**
  - (ж) **Практик боломжтой бол толилуулсан тэдгээр өмнөх тайлант үеүдээс урдах тайлант үеүдтэй холбоотойгоор хийх тохируулгын дүн;**

- (и) Хэрэв 24(а) эсвэл (б) параграфтаар шаардсан буцаах горимоор мөрдөлтийг өмнөх тодорхой нэг тайлант үед эсвэл толилуулсан тэдгээр өмнөх тайлант үеүдээс урдах тайлант үеүдэд хэрэгжүүлэх практик боломжгүй бол ийм байдалд хүргэсэн шалтгаан нөхцөл, түүнчлэн уг нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг хэзээнээс, хэрхэн мөрдөж ирсэн талаархи тайлбар тодорхойлолт.

Дараагийн тайлант үеүдийн санхүүгийн тайланд эдгээр тодруулгыг дахин давтан тусгах шаардлагагүй юм.

34. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын сайн дураараа өөрчлөлт нь (а) тухайн тайлант үед буюу өмнөх аливаа нэг тайлант үед нөлөө үзүүлдэг, (б) уг тохируулгын дүнг тодорхойлох практик боломжгүйгээс бусад тохиолдолд тэрхүү тайлант үед нөлөө үзүүлэхээр байсан, эсвэл (в) ирээдүйн тайлант үеүдэд нөлөө үзүүлж болохоор байвал байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:

- (а) Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн шинж төрөл;
- (б) Нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогын мөрдөлт нь үнэн зөв илэрхийлэл ба илүү их хамааралтай мэдээллээр хангадаг учир шалтгаан;
- (в) Толилуулсан тухайн тайлант үе болон өмнөх тайлант үе тус бүрд хэрэв практик боломжтой бол уг нөлөөлсөн санхүүгийн тайлангийн мөрийн зүйл тус бүрд хийсэн тохируулгын дүн;
- (г) Практик боломжтой бол толилуулсан тэдгээр өмнөх тайлант үеүдээс урдах тайлант үеүдтэй холбоотойгоор хийх тохируулгын дүн;
- (д) Буцаах горимоор мөрдөлтийг өмнөх тодорхой нэг тайлант үед эсвэл толилуулсан тэдгээр өмнөх тайлант үеүдээс урдах тайлант үеүдэд хэрэгжүүлэх практик боломжгүй бол ийм байдалд хүргэсэн шалтгаан нөхцөл, түүнчлэн уг нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг хэзээнээс, хэрхэн мөрдөж ирсэн талаархи тайлбар тодорхойлолт.

Дараагийн тайлант үеүдийн санхүүгийн тайланд эдгээр тодруулгыг дахин давтан тусгах шаардлагагүй юм.

35. Гаргасан боловч хараахан хүчин төгөлдөр болоогүй шинэ УСНББОУС-ыг мөрдөөгүй тохиолдолд байгууллага нь доорх зүйлсийг тодруулна:

- (а) Ингэж мөрдөөгүй тухай; ба
- (б) Шинэ Стандартыг мөрдсөнөөр тэрхүү анх удаа мөрдөж эхлэх тайлант үед тухайн байгууллагын санхүүгийн тайланд үзүүлэх боломжит нөлөөг үнэлэхэд хамааралтай одоо мэдэгдэж байгаа буюу ул үндэслэлтэйгээр тооцоолж болох мэдээлэл.



НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН  
ТООЦООЛЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА АЛДАА

36. 35-р параграфыг даган мөрдөхдөө байгууллага нь дараах зүйлсийг тодруулах эсэхийг харгалзан үздэг:
- (a) Шинэ УСНББОУС-ын нэр;
  - (б) Нягтлан бодох бүртгэлийн бодлогод ойрын үед хийх өөрчлөлт буюу өөрчлөлтүүдийн шинж төрөл;
  - (в) Уг Стандартыг мөрдөхийг шаардсан огноо;
  - (г) Уг Стандартыг анх удаа мөрдөхөөр төлөвлөж байгаа огноо;
  - (д) Доорх зүйлсийн аль нэгийг:
    - (i) Стандартыг анх удаа мөрдсөнөөр тухайн байгууллагын санхүүгийн тайланд үзүүлэхээр хүлээгдэж буй нөлөөний тухай хэлэлцүүлэг; эсвэл
    - (ii) хэрэв уг нөлөөг мэдэгдэхгүй буюу үндэслэлтэйгээр тооцоолох боломжгүй бол тийм нөлөөний талаархи тайлбар мэдэгдэл.

**Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт**

37. Үйлчилгээ үзүүлэх, худалдаа буюу бусад үйл ажиллагааг эрхлэн явуулахад тулгардаг угийн тодорхойгүй байдлын улмаас санхүүгийн тайлан дахь олон зүйлсийг нарийн оновчтой хэмжиж чадахгүй боловч зөвхөн ойролцоогоор тооцоолж чаддаг. Тооцоолол нь хамгийн сүүлийн үеийн байдлаар бэлэн байгаа, найдвартай мэдээлэлд үндэслэсэн шүүн тунгаалтыг агуулдаг. Тухайлбал; дараах зүйлсийн хувьд тооцоолол хийх шаардлагатай байж болно:
- (a) Засгийн газарт орох татварын орлого;
  - (б) Үл цуглуулагдах татвараас үүсэх найдваргүй авлага;
  - (в) Бараа материалын хоцрогдол;
  - (г) Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнэ;
  - (д) Элэгдүүлэх хөрөнгийн тооцоолсон ашиглалтын хугацааны эсвэл уг хөрөнгөнд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг ашиглан зарцуулах хүлээгдэж буй төлөв байдал, эсвэл замын барилгын ажлын гүйцэтгэлийн хувийн жин;
  - (e) Баталгааны үүрэг.
38. Ул үндэслэлтэй тооцоолол ашиглах нь санхүүгийн тайлан бэлтгэх ажиллагааны чухал хэсэг бөгөөд түүний найдвартай байдлыг алдагдуулдаггүй.<sup>1</sup>

---

<sup>1</sup> Найдвартай мэдээлэл нь материаллаг алдаа ба туйлшралаас ангид байх бөгөөд өөрийн илэрхийлэхээр зориулагдсан буюу илэрхийлнэ гэж ул үндэслэлтэйгээр хүлээж болох зүйлсийг үнэн зөв илэрхийлэхдээ хэрэглэгчдээс хамаардаг байж болох юм.

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН  
ТООЦООЛЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА АЛДАА

39. Тооцоолол хийсэн үеийн нөхцөл байдал өөрчлөгдсөн эсвэл шинэ мэдээлэл буюу илүү өөр туршлагын үр дүнд тооцооллыг хянан засварлах шаардлагатай байж болно. Тооцооллын хянан засварлалт нь өөрийн мөн чанараараа өмнөх тайлант үеүдтэй холбоогүй бөгөөд алдааны засварлалт ч биш юм.
40. Мөрддөг хэмжилтийн суурийн өөрчлөлт нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт мөн боловч нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт биш юм. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтөөс ялгахад төвөгтэй байх тохиолдолд уг өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзнэ.
41. **42-р параграфт зааснаас бусад, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтийн үр нөлөөг дараах байдлаар ашиг, алдагдалд тусгаж, гүйцээх горимоор хүлээн зөвшөөрнө:**
- (а) **Хэрэв өөрчлөлт нь зөвхөн тэр тайлант үедээ нөлөө үзүүлдэг бол өөрчлөлт гарсан уг тайлант үед нь; эсвэл**
- (б) **Хэрэв өөрчлөлт нь өөрчлөлт гарсан тэр тайлант үе болон ирээдүйн тайлант үеүдийн аль алинд нөлөө үзүүлдэг бол өөрчлөлт гарсан уг тайлант үе болон ирээдүйн тайлант үеүдэд нь.**
42. **Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт нь хөрөнгө, өр төлбөрт өөрчлөлт ороход хүргэдэг буюу цэвэр хөрөнгө/өмчийн зүйлд хамааралтай байх тэр хэмжээгээр холбогдох хөрөнгө, өр төлбөр буюу цэвэр хөрөнгө/өмчийн дансны үнийг тохируулах замаар уг өөрчлөлт гарсан тайлант үед түүнийг хүлээн зөвшөөрнө.**
43. Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтийн үр нөлөөг гүйцээх горимоор хүлээн зөвшөөрөх гэдэг нь тооцооллын өөрчлөлт гарсан өдрөөс эхлэн уг өөрчлөлтийг ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдалд мөрдөхийг хэлдэг. Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт нь зөвхөн тухайн тайлант үеийн ашиг, алдагдалд эсвэл тухайн тайлант үе болон ирээдүйн тайлант үеүдийн аль алины ашиг, алдагдалд нөлөөлж болох юм. Жишээлбэл, найдваргүй авлагын дүнгийн тооцооллын өөрчлөлт нь зөвхөн тухайн тайлант үеийн ашиг, алдагдалд нөлөөлдөг, иймээс түүнийг зөвхөн тухайн тайланд үед хүлээн зөвшөөрнө. Харин элэгдүүлэх хөрөнгийн тооцоолсон ашиглалтын хугацааны эсвэл уг хөрөнгөнд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг ашиглан зарцуулах хүлээгдэж буй төлөв байдлын өөрчлөлт нь тухайн тайлант үеийн, түүнчлэн тэрхүү хөрөнгийн үлдэж буй ашиглалтын хугацааны турш дахь ирээдүйн тайлант үе бүрийн элэгдлийн зардалд нөлөөлдөг. Хоёр тохиолдлын аль алины хувьд, тухайн тайлант үед хамаарах уг өөрчлөлтийн үр нөлөөг тайлант үеийн орлого,

---

Найдвартай байдлын тайлбарын талаархи шилжилтийн арга хандлагыг УСНББОУС 1-ийн ДҮ16-р параграфт авч хэлэлцсэн.

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН  
ТООЦООЛЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА АЛДАА

зардлаар хүлээн зөвшөөрнө. Ирээдүйн тайлант үеүдэд үзүүлэх үр нөлөө хэрэв байгаа бол түүнийг тэдгээр ирээдүйн тайлант үеүдэд орлого, зардлаар хүлээн зөвшөөрнө.

### **Тодруулга**

44. **Байгууллага нь тухайн тайлант үед нөлөө үзүүлэх буюу ирээдүйн тайлант үеүдэд нөлөө үзүүлэхээр хүлээгдэж буй нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтийн шинж төрөл ба дүнг тодруулна. Гэвч ирээдүйн тайлант үеүдэд үзүүлэх үр нөлөөг тооцоолох практик боломжгүй тохиолдолд тэдгээр үр нөлөөний тодруулгаас бусад тодруулгыг хийнэ.**
45. **Тооцоолох практик боломжгүйн улмаас ирээдүйн тайлант үеүд дэх үр нөлөөний дүнг тодруулаагүй бол байгууллага нь энэ тухай тодруулга хийнэ.**

### **Алдаа**

46. Алдаа нь санхүүгийн тайлангийн элементүүдийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, толилуулга болон тодруулгатай холбоотойгоор үүсэж болно. Санхүүгийн тайлан нь материаллаг алдааг эсвэл байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тухайлсан тодорхой нэг толилуулгад хүрэхийн тулд санаатайгаар хийсэн материаллаг бус алдааг агуулж байвал УСНББОУС-тай үл нийцнэ. Тайлант үед илрүүлсэн уг тайлант үеийн боломжит алдааг тухайн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрөхөөс өмнө засварладаг. Гэвч заримдаа, материаллаг алдааг дараагийн тайлант үе хүртэл илрүүлж чаддаггүй бөгөөд тэдгээр өмнөх үеийн алдааг тухайн дараагийн тайлант үеийн санхүүгийн тайланд толилуулсан зэрэгцүүлэгдэх мэдээлэлд засварладаг (47-52-р параграфыг үзнэ үү).
47. **48-р параграфт зааснаас бусад тохиолдолд, байгууллага нь өмнөх тайлант үеийн материаллаг алдааг илрүүлсэний дараах ба гаргахыг зөвшөөрсөн эхний иж бүрэн санхүүгийн тайланд уг алдааг доорх байдлаар буцаах горимоор засварлана:**
- (a) **Алдаа гарсан уг өмнөх тайлант үед (үеүдэд) толилуулсан зэрэгцүүлэгдэх дүнг дахин тайлагнах;**
  - (б) **Хэрэв алдаа нь толилуулсан хамгийн эхний өмнөх тайлант үеэс урд өмнө гарч тохиолдсон бол тухайн толилуулсан хамгийн эхний өмнөх тайлант үеийн хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн эхний үлдэгдлийг дахин тайлагнана.**

### **Буцаан дахин тайлагналтын хязгаарлагдмал талууд**

48. **Алдааны тодорхой нэг тайлант үед үзүүлэх үр нөлөөг эсвэл нийт хуримтлагдсан үр нөлөөг тодорхойлох практик боломжгүй байхаас**

**бусад тохиолдолд буцаан дахин тайлагнаснаар уг өмнөх тайлант үеийн алдааг засварлана.**

49. **Толилуулсан нэг буюу хэд хэдэн өмнөх тайлант үеүдийн зэрэгцүүлэгдэх мэдээлэлд алдааны үзүүлэх тодорхой нэг тайлант үеийн үр нөлөөг тодорхойлох практик боломжгүй тохиолдолд байгууллага нь буцаан дахин тайлагнах практик боломжтой хамгийн эхний тайлант үеийн (магадгүй, тухайн тайлант үеийн) хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн эхний үлдэгдлүүдийг дахин тайлагнана.**
50. **Өмнөх бүх тайлант үеүдэд алдааны үзүүлэх нийт хуримтлагдсан үр нөлөөг тухайн тайлант үеийн эхний байдлаар тодорхойлох практик боломжгүй тохиолдолд байгууллага нь практик боломжтой хамгийн эхний өмнөх тайлант үеэс эхлэн уг алдааг гүйцээх горимоор засварлахын тулд тэдгээр зэрэгцүүлэгдэх мэдээллийг дахин тайлагнана.**
51. Өмнөх тайлант үеийн алдааны засварлалтыг уг алдааг илрүүлсэн тайлант үеийн ашиг, алдагдалд оруулахгүй. Түүхэн санхүүгийн мэдээний тойм гэх мэт өмнөх тайлант үеүдийн талаархи аливаа бусад мэдээллийг практик боломжтой аль болох олон тайлант үеүдэд бас буцаан дахин тайлагнана.
52. Өмнөх бүх тайлант үеүдийн хувьд алдааны (жишээлбэл; нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдөхөд гаргасан алдаа) дүнг тодорхойлох практик боломжгүй тохиолдолд байгууллага нь 50-р параграфт заасны дагуу практик боломжтой хамгийн эхний өмнөх тайлант үеэс эхлэн тэдгээр зэрэгцүүлэгдэх мэдээллийг гүйцээх горимоор дахин тайлагнана. Ингэснээр хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчид хийгдэх нийт хуримтлагдсан дахин тайлагналтын зарим хэсгийг, өөрөөр хэлбэл практик боломжтой тэрхүү тайлант үеэс урд өмнөх хугацаанд хамаарах хэсгийг харгалзан үзэж тусгахгүй. Нэг буюу хэд хэдэн өмнөх тайлант үеүдийн хувьд алдааг засварлах практик боломжгүй тохиолдлын талаархи заавар удирдамжийг 55-58-р параграфт заасан.
53. Алдааны засварлалт нь нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтөөс ялгаатай юм. Нягтлан бодох бүртгэлийн тооцоолол нь өөрийн мөн чанараараа ойролцоо тооцолт бөгөөд өөр бусад нэмэлт мэдээлэл мэдэгдэж, тодорхой болсноор түүнд засвар өөрчлөлт хийхийг шаарддаг байж болно. Жишээлбэл, болзошгүй үр дагаврын хувьд хүлээн зөвшөөрсөн олз буюу гарз нь алдааны засварлалт биш юм.

#### **Өмнөх тайлант үеийн алдааны тодруулга**

54. **47-р параграфыг даган мөрдөх үедээ байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:**
- (а) **Өмнөх тайлант үеийн алдааны шинж төрөл;**

- (б) Толилуулсан өмнөх тайлант үе тус бүрд хэрэв практик боломжтой бол уг нөлөөлсөн санхүүгийн тайлангийн мөрийн зүйл тус бүрд хийсэн алдааны засварлалтын дүн;
- (в) Толилуулсан хамгийн эхний, өмнөх тайлант үеийн эхэн дэх алдааны засварлалтын дүн;
- (г) Хэрэв өмнөх тодорхой нэг тайлант үеийн хувьд буцаан дахин тайлагнах практик боломжгүй бол ийм байдалд хүргэсэн шалтгаан нөхцөл, түүнчлэн уг алдааг хэзээ, хэрхэн засварласан талаархи тайлбар тодорхойлолт.

**Дараагийн тайлант үеүдийн санхүүгийн тайланд эдгээр тодруулгыг дахин давтан тусгах шаардлагагүй юм.**

### **Буцаах горимоор мөрдөлт ба буцаан дахин тайлагналтын практик боломжгүй байдал**

- 55. Тухайн тайлант үетэй зэрэгцүүлэх боломжтой болгохын тулд өмнөх нэг буюу хэд хэдэн тайлант үеүдийн зэрэгцүүлэгдэх мэдээллийг зарим тохиолдолд тохируулах практик боломжгүй байдаг. Жишээлбэл; нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг буцаах горимоор мөрдөх (үүн дотроо 56-58-р параграфын зорилгоор өмнөх тайлант үеүдээс гүйцээх горимоор мөрдөх) эсвэл өмнөх тайлант үеийн алдааг засварлахын тулд буцаан дахин тайлагнах боломжийг олгох тийм байдлаар өмнөх тайлант үед (үеүдэд) мэдээг цуглуулаагүй байж болох юм.
- 56. Ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдалтай холбоотойгоор хүлээн зөвшөөрсөн буюу тодруулсан санхүүгийн тайлангийн элементүүдэд нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдөхдөө тооцоолол хийх шаардлага байнга гардаг. Тооцоолол нь угаасаа субъектив шинжтэй бөгөөд тухайн тайлант үеийн эцсээс хойш тооцоолол хийж болох юм. Холбогдох ажил гүйлгээ, бусад үйл явдал болон нөхцөл байдал тохиолдсоноос хойш нилээд урт хугацаа өнгөрсөн байж болох учраас нягтлан бодох бүртгэлийн бодлогыг буцаах горимоор мөрдөх буюу өмнөх тайлант үеийн алдааг засварлахын тулд буцаан дахин тайлагнах үед тооцоолол хийхэд нилээд төвөгтэй байдаг. Гэвч өмнөх тайлант үеүдтэй холбоотой тооцооллын зорилго нь тухайн тайлант үед хийсэн тооцооллын зорилготой ижил хэвээр байна. Тодруулбал, тооцооллын зорилго нь тухайн ажил гүйлгээ, бусад үйл явдал буюу нөхцөл байдал гарч тохиолдсон үед оршин байсан тэрхүү нөхцөл байдлыг тусгах явдал юм.
- 57. Иймээс нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг буцаах горимоор мөрдөх эсвэл өмнөх тайлант үеийн алдааг засварлах нь дараах нөхцөл бүхий мэдээллийг өөр бусад мэдээллээс ялган зааглахыг шаарддаг:
  - (а) Ажил гүйлгээ, бусад үйл явдал буюу нөхцөл байдал гарч тохиолдсон тэр өдөр оршин байсан нөхцөл байдлын талаархи нотолгоогоор хангах; ба

- (б) Уг өмнөх тайлант үеийн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрөх үед бэлэн боломжтой байсан.

Зарим тооцооллын хувьд (жишээлбэл, ажиглаж болох үнэ буюу ажиглаж болох орц мэдээнд үндэслээгүй бодит үнэ цэнийн тооцоолол) эдгээр мэдээллийн төрлүүдийг өөр хооронд нь ялган зааглах практик боломжгүй байдаг. Буцаах горимоор мөрдөлт буюу буцаан дахин тайлагналт нь мэдэгдэхүйц тооцоолол хийхийг шаарддаг бөгөөд ийм тооцооллын хувьд энэхүү хоёр төрлийн мэдээллийг өөр хооронд нь ялган зааглах боломжгүй бол нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг буцаах горимоор мөрдөх эсвэл өмнөх тайлант үеийн алдааг буцаах горимоор засварлах практик боломжгүй гэж үзнэ.

58. Нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг өмнөх тайлант үе рүү буцаах горимоор мөрдөх буюу алдааг өмнөх тайлант үеийн хувьд засварлах тохиолдолд уг өмнөх тайлант үед удирдлагын санаа зорилго ямар байсан талаар таамаглах эсвэл тэрхүү өмнөх тайлант үед хүлээн зөвшөөрсөн, хэмжсэн, тодруулсан дүнгүүдийг тооцоолох гэх мэтээр нэгэнт өнгөрсөн зүйлийн талаархи хожмын мэдээг ашиглахгүй байвал зохино. Жишээлбэл; засгийн газрын барилгыг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэж ангилахдаа (энэ барилгыг өмнө нь үндсэн хөрөнгө гэж ангилж байсан) байгууллага нь өмнөх тайлант үеийн алдааг засварласан тохиолдолд тухайн байгууллагын удирдлага нь тэрхүү барилгыг эзэн-ашигладаг оффисын барилга байдлаар ашиглахаар сүүлд шийдвэрлэсэн бол тус байгууллага нь тэрхүү тайлант үед уг ангиллын суурийг өөрчлөхгүй. Түүнчлэн, байгууллага нь засгийн газрын үйл ажиллагааны улмаас үүссэн бохирдлыг цэвэрлэх зардлын нөөцийн хувьд өр төлбөрийг УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-ийн дагуу тооцоолохдоо, өмнөх тайлант үеийн алдааг засварладаг тохиолдолд тухайн байгууллага нь дараагийн тайлант үед тэнгисийн цэргийн хангамжийн усан онгоцноос гоожсон ба уг өмнөх тайлант үеийн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрснөөс хойш мэдэгдсэн, хэвийн бус их хэмжээний газрын тосны талаархи мэдээллийг харгалзан тусгахгүй. Өмнөх тайлант үеүдэд толилуулсан зэрэгцүүлэгдэх мэдээллийг нэмж өөрчлөх үед байнга томоохон тооцоолол хийх шаардлагатай болдог нь тухайн зэрэгцүүлэгдэх мэдээллийн найдвартай тохируулга буюу засварлалтанд саад учруулахгүй юм.

## Хүчин төгөлдөр болох хугацаа

59. **Байгууллага нь энэхүү Стандартыг 2008 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2008 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.**
- 59A. **2010 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар 9, 11, 14-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2011 оны 01 дүгээр**

сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө.

- 59Б. 2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-ийн үр дүнд 60-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед УСНББОУС 33-ыг мөрдсөн бол уг нэмэлт өөрчлөлтийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.
- 59В. 2016 оны 4 дүгээр сард гаргасан УСНББОУС 2015-ын *Сайжруулалтууд*-аар 7, 10, 12, 14, 15, 17, 34-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулж, 13-р параграфыг хассан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 59Г. 2016 оны 4 дүгээр сард гаргасан УСНББОУС-ын *Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 5, 6-р параграфуудыг хассан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
60. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

### **УСНББОУС 3 (2000)-аас татгалзах**

61. Энэ Стандарт нь 2000 онд гаргасан УСНББОУС 3, *Тайлант Үеийн Цэвэр Ашиг* буюу *Алдагдал, Суурь Алдаа ба Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Өөрчлөлт*-ийг орлоно.

**Хавсралт**

**Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт**

[Хассан]



## Дүгнэлтийн Үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 3-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### **НББОУС3-ийн Ерөнхий Сайжруулалтын Төсөл 2003-ын үр дүнд УСНББОУС 3-ыг хянан засварласан.**

#### *Оршил*

- ДҮ1. УСНББОУС3-ийн СТОУС-тай нийцүүлэх хөтөлбөр нь УСНББОУС3-ийн ажлын хөтөлбөрийн чухал элемент юм. УСНББОУС3-ийн бодлого нь улсын секторын байгууллагуудад тохиромжтой тохиолдолд НББОУС3-өөс гаргасан СТОУС-тай аккруэл суурьт УСНББОУС-ыг нийцүүлэх явдал юм.
- ДҮ2. Улсын секторын хувьд гажих тусгай учир шалтгаан байхаас бусад тохиолдолд СТОУС-тай нийцүүлсэн, аккруэл суурьт УСНББОУС нь СТОУС-ын шаардлага, бүтэц, текстийг тэр хэвээр хадгална. СТОУС-ын шаардлага буюу нэр томъёо нь улсын секторт тохиромжгүй эсвэл улсын секторын хувьд зарим тодорхой шаардлагуудыг үлгэрчлэн харуулахын тулд нэмэлт тайлбар буюу жишээ оруулах шаардлагатай тохиолдолд адилтгах СТОУС-аас гаждаг. УСНББОУС-ууд ба тэдгээртэй адилтгах СТОУС-уудын хоорондох ялгаатай талуудыг УСНББОУС нэг бүрд тусган оруулсан *СТОУС-тай Харьцуулалт*-д тодорхойлсон. НББОУС 8-тай хийсэн харьцуулалт нь НББОУС 8-ын 2003 оны 12 дугаар сарын хувилбарыг лавлагаа болгосон бөгөөд өөр бусад хувилбартай харьцуулаагүй болно.
- ДҮ3. 2002 оны 5 дугаар сард өөрийн Ерөнхий Сайжруулалтын Төслийн нэг хэсэг болгон НББОУС3 нь 13-н НББОУС<sup>2</sup>-д оруулахаар санал болгосон нэмэлт өөрчлөлтийн саналын төслийг гаргасан. НББОУС3-ийн Ерөнхий Сайжруулалтын Төслийн зорилго нь “Стандартуудын хүрээн дэх сонголтод олон хувилбарууд, илүүдэл зүйлс, зөрчилтэй заалтуудыг арилгах буюу бууруулах, нийцүүлэлтийн зарим асуудлуудыг шийдэх ба бусад сайжруулалтыг хийх”-д оршино. НББОУС-ын эцсийн хувилбарыг 2003 оны 12 дугаар сард гаргасан.
- ДҮ4. 2000 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 3 нь НББОУС 8, *Тайлант Үеийн Цэвэр Ашиг буюу Алдагдал, Суурь Алдаа ба Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Өөрчлөлт* (1993 онд хянан засварласан)-д үндэслэсэн. НББОУС 8-ыг 2003 оны 12 дугаар сард НББОУС 8, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* гэж нэрлэн дахин гаргасан. УСНББОУС3-ийн өмнөх

---

<sup>2</sup> НББОУС3-ийн өмнөх байгууллага болох НББОУСХ-ноос НББОУС-ыг гаргасан. НББОУС3-өөс гаргасан стандартуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) гэж нэрлэдэг. СТОУС-ыг НББОУС3 нь СТОУС, НББОУС, Стандартын Тайлбаруудаас бүрдэнэ гэж тодорхойлсон. Зарим тохиолдолд НББОУС3 нь НББОУС-ыг сольж орлуулахгүй, харин нэмэлт өөрчлөлт оруулдаг бөгөөд ингэснээр хуучин НББОУС-ын дугаарлалт хэвээр үлддэг.

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН  
ТООЦООЛЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА АЛДАА

байгууллага болох Улсын Секторын Хороо (УСХ)<sup>3</sup> нь 2003 оны 12 дугаар сард гаргасан, сайжруулсан НББОУС-тай тохиромжтой хэмжээгээр УСНББОУС-ыг нийцүүлэхийн тулд УСНББОУС-ыг сайжруулах төслийг 2003 оны эцсээр хэрэгжүүлж эхэлсэн.

- ДҮ5. УСНББОУС3 нь уг сайжруулсан НББОУС 8-ыг нягталж шалгаад уг НББОУС-ыг ингэж хянан засварлах болсон НББОУС3-ийн учир шалтгаан болон хийсэн нэмэлт өөрчлөлттэй ерөнхийдөө санал нэгдсэн. (НББОУС3-ийн Дүгнэлтийн Үндэслэлийг энд дахин нийтлээгүй болно. НББОУС3-ийн *Цогц Захиалгын Үйлчилгээ*-гээр захиалагч нар нь [www.iasb.org](http://www.iasb.org) хаягаар орж, НББОУС3-ийн вэб сайтаас Дүгнэлтийн Үндэслэлийг үзэж болно). УСНББОУС нь адилтгах НББОУС-аас гажих тохиолдолд улсын секторын хувьд гажих тусгай учир шалтгааныг Дүгнэлтийн Үндэслэлд тайлбарладаг.
- ДҮ6. 2003 оны 12 дугаар сараас хойш гаргасан СТОУС-уудын үр дүн болох нэмэлт өөрчлөлтүүдийг УСНББОУС 3-д тусган оруулаагүй байна. Яагаад гэвэл, УСНББОУС3 нь тэдгээр СТОУС-уудын шаардлагуудыг нягтлан шалгаж, улсын секторын байгууллагуудад мөрдөгдөх боломжит байдлын талаар өөрийн үзэл бодлыг хараахан илэрхийлээгүй байгаа юм.

**2008 онд гаргасан, НББОУС3-ийн СТОУС-ын Сайжруулалтууд-ын үр дүнд УСНББОУС 3-д хийсэн хянан засварлалт**

- ДҮ7. УСНББОУС3 нь 2008 оны 5 дугаар сард НББОУС3-өөс гаргасан СТОУС-ын *Сайжруулалтууд*-д тусгасан, НББОУС 8-ын хянан засварлалтыг нягталж шалгаад уг Стандартыг хянан засварлах болсон НББОУС3-ийн учир шалтгаантай ерөнхийдөө санал нийлсэн. УСНББОУС3 нь уг нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдөхгүй байх улсын секторын тусгай учир шалтгаан байхгүй гэж дүгнэсэн.

**Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал (УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд)-ыг хэвлэн гаргасны үр дүнд УСНББОУС 3-д хийсэн хянан засварлалт**

- ДҮ8. *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал* (Онолын Үзэл Баримтлал)-ыг хэвлэн гаргасны дараа, УСНББОУС3 нь уг Онолын Үзэл Баримтлалын эхний дөрвөн бүлгийг тусгахын тулд УСНББОУС-уудад өөрчлөлт оруулах хязгаарлагдмал цар хүрээ бүхий төслийг эхлүүлсэн. Эдгээр бүлэгт үүрэг ба бүрэн эрх, зорилго ба хэрэглэгчид, чанарын шинжүүд (ЧШ), нийтлэг зорилготой санхүүгийн тайлан дахь мэдээллийн хязгаарлагдмал талууд, тайлагнагч байгууллагыг авч үзсэн. УСНББОУС3 нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг Саналын Төсөл (СТ) 58, *УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд*-д санал болгосон.

<sup>3</sup> ДНБХ-ны Зөвлөл нь УСХ-г стандарт тогтоох бие даасан зөвлөл болгохын тулд түүний бүрэн эрхийг 2004 оны 11 дүгээр сард өөрчилснөөр УСХ нь УСНББОУС3 болсон.

- ДҮ9. Ажил гүйлгээ, бусад үйл явдал буюу нөхцөл байдалд тусгайлан мөрдөх УСНББОУС байхгүй тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн бодлогыг боловсруулах эхний түвшний шаардлагуудыг УСНББОУС 3-ын 12-р параграфт заасан байдаг. Хамааралтай ба найдвартай мэдээллийг бий болгох нягтлан бодох бүртгэлийн бодлогыг боловсруулж, мөрдөхдөө удирдлага нь өөрийн шүүн тунгаалтыг ашиглах хэрэгтэй гэдгийг УСНББОУС-ын 2006 оны хувилбарт тусгайлан заасан. УСНББОУС3 нь Онолын Үзэл Баримтлалтай нийцүүлэхийн тулд найдвартай байдал гэсэн хэллэгийг үнэн зөв илэрхийлэлт гэсэн хэллэгээр сольж орлуулахаар шийдвэрлэсэн. Чанарын үндсэн болон нэмэгдүүлэх шинжүүдийг ялган зааглахгүй байх өөрийн шийдвэртэй нийцүүлэхийн тулд УСНББОУС3 нь нийтлэг зорилготой санхүүгийн тайланд тусгасан мэдээллийн бусад чанарын шинжүүд (ЧШ) ба мэдээллийн хязгаарлагдмал талуудыг 12-р параграфт тусгахаар шийдвэрлэсэн. СТ 58-д санал өгөгчид нь иж бүрэн ЧШ-үүд болон хязгаарлагдмал талуудыг тусган илэрхийлэхийн тулд бүх УСНББОУС-ууд дахь уг хэллэгийг засварлан өөрчлөх хэрэгтэй гэж үзсэн. Санхүүгийн тайлагналын зорилтуудад хүрэхэд ач холбогдолтой мэдээллийг уг нийтлэг зорилготой санхүүгийн тайланд тусгахын тулд ЧШ бүр нь бусад ЧШ-ийн салшгүй нэг хэсэг байх бөгөөд тэдгээртэй хамтран үйлчлэх ёстой гэдгийг Онолын Үзэл Баримтлалд тэмдэглэсэн. Гэхдээ ийм харилцан үйлчлэл нь тухайн нөхцөл байдлаас хамааран тодорхой нэг ЧШ их эсвэл бага ач холбогдолтой байхад саад учруулахгүй юм. Иймээс УСНББОУС3 нь нэг буюу хэд хэдэн ЧШ-ийг харилцан лавлагаа болгох бүрд бүх ЧШ-үүд болон хязгаарлагдмал талуудад лавлагаа үүсгэх хэрэггүй гэж дүгнэсэн.
- ДҮ10. УСНББОУС 3 нь найдвартай байдлын олон шинжүүдийг, үүн дотроо эдийн засгийн мөн чанар, төв голч, оновчтой, иж бүрэн байдлын шинжүүдийг мөн жагсаан харуулдаг байсан. Эдгээр шинжүүдийг уг хянан засварласан УСНББОУС 3-д дэлгэрэнгүй жагсаан харуулах хэрэгтэй эсхийг УСНББОУС3 харгалзан үзсэн. УСНББОУС3 нь эдгээр шинжүүдийн үнэ цэнийг дурдан мэдэгдсэн боловч Онолын Үзэл Баримтлалд тэдгээрийг ЧШ гэж тусгайлан тодорхойлоогүй, харин УСНББОУС 1-ийн Хавсралт А-д тусгайлан зааж, тайлбарласан гэдгийг тэмдэглэсэн.
- ДҮ11. “Юмс үзэгдлийн дүрслэн илэрхийлэлт нь иж бүрэн, төв голч, материаллаг алдаагүй байх үед үнэн зөв илэрхийлэл болно”, түүнчлэн “эдийн засгийн буюу бусад үзэгдлийг үнэн зөв илэрхийлэх мэдээлэл нь уг суурь ажил гүйлгээ, бусад үйл явдал, үйл ажиллагаа буюу нөхцөл байдлын мөн чанарыг тусган илэрхийлнэ – энэ нь түүний хуулийн хэлбэртэй ямагт ижил байх албагүй юм” гэдгийг Онолын Үзэл Баримтлалд тайлбарласан байдаг. Иймээс хэлбэрээс илүү мөн чанар нь нийтлэг зорилготой санхүүгийн тайланд тусгасан мэдээлэлд байх ёстой гол шинж хэвээр байна. Үнэн зөв илэрхийлэл гэсэн ойлголтонд нэгэнт агуулагдаж байгаа учраас мөн чанарыг тусдаа буюу нэмэлт ЧШ гэж тодорхойлдоггүй.
- ДҮ12. Оновчтой байдал гэсэн ойлголт нь үнэн зөв толилуулгын бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд төв голч шинжийн тайлбарт мөн багтан тусгагдсан

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН  
ТООЦООЛЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА АЛДАА

бөгөөд тодорхойгүй байдлыг авч үзэхдээ анхаарал болгоомжтой хандах шаардлагыг илэрхийлсэн гэж УСНББОУСЗ үздэг. Иймээс УСНББОУСЗ нь эдийн засгийн мөн чанар, төв голч, оновчтой, иж бүрэн гэсэн шинжүүдийг 12-р параграфт дэлгэрэнгүй дурдах шаардлагагүй гэж дүгнэсэн.

ДҮ13. Ажил гүйлгээ, бусад үйл явдал буюу нөхцөл байдалд тусгайлан мөрдөх УСНББОУС байхгүй тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн бодлогыг боловсруулахдаа түүний мөрдөгдөх боломжит байдлыг хувьд удирдлага нь лавлагаа болгох ба харгалзах эх сурвалжийг 14-р параграфт заасан байдаг. Бусад УСНББОУС эсвэл Онолын Үзэл Баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт, хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийн шалгуурыг удирдлагад чиглэл болгон өгөх хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн. Онолын Үзэл Баримтлалд заасан, тодорхойлолт, хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийн шалгуурыг тусгахын тулд УСНББОУС-уудыг хараахан шинэчлэн баяжуулаагүй байгаа гэдгийг УСНББОУСЗ мэдэгдсэн. Гэхдээ УСНББОУСЗ-ийн хамгийн сүүлийн үеийн шинэчлэл өөрчлөлтийг Онолын Үзэл Баримтлалд тусгасан тул удирдлага нь энэхүү эх сурвалжаас чиглэл авах хэрэгтэй гэж УСНББОУСЗ дүгнэсэн.

ДҮ14. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын боловсруулалт ба мөрдөлтийн хувьд шүүн тунгаалт хийхдээ, удирдлага нь стандарт-тогтоох бусад байгууллагуудын хамгийн сүүлийн үеийн тунхаглалуудыг, хэрэв УСНББОУС-д үндэслэсэн эх сурвалжтай зөрчилдөхөөргүй бол харгалзан үзэхийг 15-р параграфтаар зөвшөөрсөн байдаг. УСНББОУСЗ нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-ийн тунхаглалуудын жишээг тэр хэвээр авах хэрэгтэй эсэхийг харгалзан үзсэн. НББОУСЗ-ийн Онолын Үзэл Баримтлалыг хянан засварлах ажил энэ үед хараахан дуусаагүй байгаа тул УСНББОУСЗ нь УСНББОУСЗ-ийн Онолын Үзэл Баримтлал ба НББОУСЗ-ийн одоо хянан засварлаж буй Онолын Үзэл Баримтлал хоорондоо зөрүүтэй гэж дүгнэсэн. Иймээс НББОУСЗ-ийн Онолын Үзэл Баримтлалд үндэслэсэн, нягтлан бодох бүртгэлийн бодлогын боловсруулалт ба мөрдөлт нь улсын секторын хувьд ямагт тохиромжтой биш байж болох юм. СТ 58-д санал өгөгчдийн гаргасан санал зөвлөмжийн хариу болгон УСНББОУСЗ нь УСНББОУСЗ-ийн Онолын Үзэл Баримтлал бол НББОУСЗ-ийн Онолын Үзэл Баримталын дагалдах баримт бичиг биш гэдгийг мөн дахин баталгаажуулан мэдэгдсэн. УСНББОУСЗ нь 15-р параграфт дурдсан, НББОУСЗ-ийн бусад тунхаглалууд, үүн дотроо СТОУС, НББОУСЗ-ийн СТОУС-ын Тайлбарын Хороо (СТОУТХ) буюу өмнөх Тайлбарын Байнгын Хороо (ТБХ)-ноос гаргасан Тайлбарууд ач холбогдолтой бөгөөд тэдгээрийг хэвээр мөрдөх хэрэгтэй гэж үзсэн.

**2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУСЗ-ийн УСНББОУС-ЫН Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 3-д хийсэн хянан засварлалт**

ДҮ15. УСНББОУСЗ нь 2016 оны 4 дүгээр сард УСНББОУС-ЫН Мөрдөгдөх Боломжит Байдал-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН  
ТООЦООЛЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА АЛДАА

байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (а) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын зэрэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р* параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

## Хэрэгжүүлэх заавар удирдамж

Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 3-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

### Алдааг буцаан дахин тайлагналт

ХЗУ1. Орлогын татвараар цуглуулсан орлого буруу байсныг байгууллага нь 20X2 онд илрүүлсэн. 20X1 онд хүлээн зөвшөөрөх байсан 6,500ТН<sup>4</sup>-ийн орлогын татварын орлогыг 20X1 онд алдаа гарган орхигдуулж, 20X2 онд орлого гэж хүлээн зөвшөөрсөн.

ХЗУ2. Байгууллагын 20X2 оны нягтлан бодох бүртгэлээр татварын орлого нь 60,000ТН (үүнд: эхний үлдэгдэлд хүлээн зөвшөөрвөл зохих 6,500ТН-ийн татвар хамаарна), зардал нь 86,500ТН байсан.

ХЗУ3. 20X1 онд байгууллага нь дараах байдлаар тайлагнасан:

	ТН
Татварын орлого	34,000
Хэрэглэгчдийн төлбөр	3,000
Бусад үйл ажиллагааны орлого	30,000
Нийт орлого	<u>67,000</u>
Зардал	<u>(60,000)</u>
Ашиг	<u>7,000</u>

ХЗУ4. 20X1 оны хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдэл нь 20,000ТН, эцсийн үлдэгдэл нь 27,000ТН байсан.

ХЗУ5. Тухайн байгууллагад өөр орлого, зардал байгаагүй.

ХЗУ6. Тухайн хугацааны туршид байгууллага нь 5,000ТН-ийн хувь нийлүүлсэн капиталтай байсан бөгөөд хуримтлагдсан ашгаас өөр бусад цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсэг байгаагүй.

### Улсын секторын байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлан

	20X2	20X1 (дахин тайлагнасан)
	ТН	ТН
Татварын орлого	53,500	40,500
Хэрэглэгчдийн төлбөр	4,000	3,000
Бусад үйл ажиллагааны орлого	40,000	30,000
Нийт орлого	<u>97,500</u>	<u>73,500</u>
Зардал	<u>(86,500)</u>	<u>(60,000)</u>
Ашиг	<u>11,000</u>	<u>13,500</u>

<sup>4</sup> Эдгээр жишээнд мөнгөн дүнг “тооцооны нэгж” (ТН)-гэж илэрхийлсэн.

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН  
ТООЦООЛЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА АЛДАА

**Улсын секторын Х байгууллагын өмчийн өөрчлөлтийн тайлан**

	Хувь нийлүүлсэн капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
	ТН	ТН	ТН
20X0 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,000	20,000	25,000
20X1 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жилийн дахин тайлагнасан ашиг	-	13,500	13,500
20X1 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,000	33,500	38,500
20X2 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жилийн ашиг	-	11,000	11,000
20X2 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,000	44,500	49,500

*Санхүүгийн тайлангийн тодруулгаас авсан ишлэл*

- 6,500ТН-ийн орлогын татварын орлогыг 20X1 оны санхүүгийн тайланд алдаа гарган тусгалгүй орхигдуулсан. Энэхүү алдааг засварлахын тулд 20X1 оны санхүүгийн тайланг дахин тайлагнасан. Тэдгээр санхүүгийн тайланд уг дахин тайлагналын үзүүлэх үр нөлөөг доор товчоолон харуулав. 20X2 онд үзүүлэх үр нөлөө байхгүй.

	20X1 онд үзүүлэх үр нөлөө	
	ТН	
Орлогын өсөлт		6,500
Ашгийн өсөлт		6,500
Авлагын өсөлт		6,500
Цэвэр хөрөнгө/өмчийн өсөлт		6,500

**Буцаах горимоор мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт**

- ХЗУ7. Одоо баригдаж буй усан цахилгаан станцыг худалдан авахтай шууд холбоотой зээлийн өртгийн бүртгэлийн хувьд өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг уг байгууллага нь 20X2 онд өөрчилсөн. Өмнөх тайлант үеүдэд байгууллага нь ийм өртөг зардлыг капиталжуулдаг байсан. Тухайн байгууллага нь одоо ийм зардлыг капиталжуулах биш, харин зардалд бүртгэхээр шийдвэрлэсэн. Уг шинэ бодлого нь санхүүгийн зардлын илүү ойлгомжтой тайлагналд хүргэх бөгөөд тухайн байгууллагын санхүүгийн тайланг илүү зэрэгцүүлэгдэх боломжтой болгосноор салбарын орон нутгийн практиктай нийцнэ гэж удирдлага дүгнэсэн.

**НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН  
ТООЦООЛЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА АЛДАА**

ХЗУ8. Тухайн байгууллага нь 20Х1 онд 2,600ТН-ийн, 20Х1 оноос өмнөх тайлант үеүдэд 5,200ТН-ийн зээлийн өртгийг капиталжуулсан. Уг цахилгаан станцын худалдан авалттай холбоотойгоор өмнөх жилүүдэд гарсан бүх зээлийн өртгийг капиталжуулж байсан.

ХЗУ9. 20Х2 оны нягтлан бодох бүртгэлээр, хүүний зардлын өмнөх ашиг нь 30,000ТН ба хүүний зардал нь 3,000ТН (энэ нь зөвхөн 20Х2 онд хамааралтай) байсан.

ХЗУ10. Цахилгаан станц ашиглалтанд ороогүй учраас байгууллага нь түүний хувьд ямар нэг элэгдлийн зардал хүлээн зөвшөөрөөгүй.

ХЗУ11. 20Х1 онд байгууллага нь дараах дүнг тайлагнасан:

	ТН
Хүүний зардлын өмнөх ашиг	18,000
Хүүний зардал	-
Ашиг	<u>18,000</u>

ХЗУ12. 20Х1 оны хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдэл нь 20,000ТН, эцсийн үлдэгдэл нь 38,000ТН байсан.

ХЗУ13. Тухайн хугацааны туршид байгууллага нь 10,000ТН-ийн хувь нийлүүлсэн капиталтай байсан бөгөөд хуримтлагдсан ашгаас өөр бусад цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсэг байгаагүй.

**Улсын секторын байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлан**

	20Х2	20Х1 (дахин тайлагнасан)
	ТН	ТН
Хүүний зардлын өмнөх ашиг	30,000	18,000
Хүүний зардал	<u>(3,000)</u>	<u>(2,600)</u>
Ашиг	<u>27,000</u>	<u>15,400</u>



НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН  
ТООЦООЛЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА АЛДАА

**Улсын секторын байгууллагын цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

	Хувь нийлүүлсэн капитал	Хуримтлагдсан ашиг (дахин тайлагнасан)	Нийт дүн
	ТН	ТН	ТН
Өмнө нь тайлагнасан байсан 20X0 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	10,000	20,000	30,000
Хүүний зардлын капиталжуулалттай холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт (Тодруулга 1)	-	(5,200)	(5,200)
20X0 оны 12-р сарын 31-ний дахин тайлагнасан үлдэгдэл	10,000	14,800	24,800
20X1 оны 12-р сарын 31-ээр дуусгавар болсон жилийн дахин тайлагнасан ашиг	-	15,400	15,400
20X1 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	10,000	30,200	40,200
20X2 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жилийн ашиг	-	27,000	27,000
20X2 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	10,000	57,200	67,200

*Санхүүгийн тайлангийн тодруулгаас авсан ишлэл*

- Усан цахилгаан станцыг худалдан авахтай холбоотой зээлийн өртгийн бүртгэлийн хувьд байгууллага нь өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг 20X2 онд өөрчилсөн. Байгууллага өмнө нь ийм өртөг зардлыг капиталжуулдаг байсан. Харин одоо уг байгууллага нь гарсан даруйд зардал гэж тайлагнахаар болсон. Энэхүү шинэ бодлого нь санхүүгийн зардлын илүү ойлгомжтой тайлагналд хүргэх бөгөөд тухайн байгууллагын санхүүгийн тайланг илүү зэрэгцүүлэгдэх боломжтой болгосноор салбарын орон нутгийн практиктай нийцэх учраас үнэн зөв илэрхийлэх ба илүү найдвартай мэдээллээр хангана гэж удирдлага дүгнэсэн. Уг нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг буцаах горимоор тайлагнасан ба 20X1 оны зэрэгцүүлэгдэх санхүүгийн тайланг дахин тайлагнасан. 20X1 онд уг өөрчлөлтийн үзүүлэх үр нөлөөг доор хүснэгтлэн харуулав. 20X1 оноос өмнөх тайлант үеүдтэй холбоотой тохируулгын дүн болох 5,200ТН-ээр 20X1 оны хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдлийг бууруулсан.

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН  
ТООЦООЛЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА АЛДАА

<i>20X1 онд үзүүлэх үр нөлөө</i>	ТН
Хүүний зардлын (өсөлт)	(2,600)
Ашгийн (бууралт)	(2,600)
<i>20X1 оноос өмнөх тайлант үеүдэд үзүүлэх үр нөлөө</i>	
Ашгийн (бууралт)	(5,200)
Барилгын ажлын явц дахь хөрөнгийн болон хуримтлагдсан ашгийн бууралт	(7,800)

**Буцаах горимоор мөрдөх практик боломжгүй тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг гүйцээх горимоор мөрдөх**

ХЗУ14. 20X2 онд байгууллага нь дахин үнэлгээний загварыг хэрэглэхийн хамтаар бүрэлдэхүүн хэсгийн хандлагыг бүрэн мөрдөх боломжтой болохын тулд үндсэн хөрөнгийг элэгдүүлэх өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчилсөн.

ХЗУ15. 20X2 оноос өмнө тухайн байгууллагын хөрөнгийн бүртгэл нь бүрэлдэхүүн хэсгийн хандлагыг бүрэн мөрдөх боломжтой байдлаар хангалттай дэлгэрэнгүй байдаггүй байсан. 20X1 оны эцэст, удирдлага нь инженерийн судалгаа хийлгэсэн ба ингэснээр уг эзэмшиж буй бүрэлдэхүүн хэсгүүд, тэдгээрийн бодит үнэ цэнэ, ашиглалтын хугацаа, тооцоолсон үлдэх өртөг, 20X2 оны эхнээс элэгдүүлэх дүнгийн талаархи мэдээллийг бүрдүүлсэн. Гэвч өмнө нь тус тусад нь тайлагнадаггүй байсан тэдгээр бүрэлдэхүүн хэсгүүдийн өртгийг найдвартайгаар тооцоолох суурийг тэрхүү судалгаагаар бүрдүүлээгүй бөгөөд уг судалгааны өмнө байсан бүртгэлүүд нь тухайн мэдээллийг бүрдүүлэх боломж олгохооргүй байсан.

ХЗУ16. Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлтийн хоёр төлөв байдал тус бүрийг хэрхэн тайлагнахыг удирдлага харгалзан үзсэн. Удирдлага нь энэхүү өөрчлөлтийг бүрэн бүрэлдэхүүн хэсгийн хандлага болгон буцаах горимоор тайлагнах эсвэл 20X2 он эхлэхээс өмнөх аливаа нэг хугацаанаас эхлэн уг өөрчлөлтийг гүйцээх горимоор тайлагнах практик боломжгүй гэдгийг тодорхойлсон. Түүнчлэн, өртгийн загвараас дахин үнэлгээний загвар болгох өөрчлөлтийг гүйцээх горимоор тайлагнах шаардлагатай байсан. Иймээс удирдлага нь уг байгууллагын нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг 20X2 оноос эхлэн гүйцээх горимоор мөрдөх хэрэгтэй гэж дүгнэсэн.

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН  
ТООЦООЛЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА АЛДАА

ХЗУ17. Нэмэлт мэдээлэл:

	ТН
<b>Үндсэн хөрөнгө</b>	
Өртөг	25,000
Элэгдэл	<u>(14,000)</u>
Дансны цэвэр үнэ	<u>11,000</u>
Гүйцээх горимоор тооцсон 20X2 оны элэгдлийн зардал (хуучин сууриар)	1,500
Инженерийн судалгааны зарим үр дүн	
Үнэлгээ	17,000
Тооцоолсон үлдэх үнэ цэнэ	3,000
Хөрөнгийн үлдсэн ашиглалтын дундаж хугацаа (жилээр)	7
Одоо байгаа үндсэн хөрөнгийн 20X2 оны элэгдлийн зардал (шинэ сууриар)	2,000

*Санхүүгийн тайлангийн тодруулгаас авсан ишлэл*

1. Байгууллага нь дахин үнэлгээний загварыг хэрэглэхийн хамтаар бүрэлдэхүүн хэсгийн хандлагыг бүрэн мөрдөх боломжтой болохын тулд үндсэн хөрөнгийг элэгдүүлэх өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг 20X2 оны эхнээс өөрчилсөн. Энэхүү бодлого нь үндсэн хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгүүдийг илүү үнэн зөв авч үздэг бөгөөд сүүлийн үеийн үнэ цэнэд үндэслэдэг учраас үнэн зөв илэрхийлэл болон илүү хамааралтай мэдээллээр хангана гэж удирдлага үзсэн. Өмнөх аливаа нэг хугацаанаас эхлэн уг бодлогыг буцаах горимоор эсвэл гүйцээх горимоор мөрдсөний үр нөлөөг тооцоолох практик боломжгүй учраас түүнийг 20X2 оны эхнээс эхлэн гүйцээх горимоор мөрдсөн. Иймээс энэхүү шинэ бодлогыг мөрдсөнөөр өмнөх тайлант үеүдэд нөлөө үзүүлэхгүй юм. Тайлант жилд үзүүлэх үр нөлөө нь (а) тухайн жилийн эхэн дэх үндсэн хөрөнгийн дансны үнийг 6,000ТН-ээр нэмэгдүүлнэ, (б) тухайн жилийн эхэнд 6,000ТН-ийн дахин үнэлгээний нөөцийг үүсгэнэ, (в) элэгдлийн зардлыг 500ТН-ээр нэмэгдүүлнэ.

## НББОУС 8-ТАЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-г НББОУС 8, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* (2003)-наас үндсэндээ бэлтгэсэн бөгөөд 2008 оны 5 дугаар сард гаргасан, *СТОУС-ын Сайжруулалтууд*-ын нэг хэсэг байдлаар НББОУС 8-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг үүнд тусгасан болно. УСНББОУС 3 ба НББОУС 8-ын хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- УСНББОУС 3 нь зарим тохиолдолд НББОУС 8-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь УСНББОУС 3 дахь “санхүүгийн үр дүнгийн тайлан”, “хуримтлагдсан ашиг, алдагдал” ба “цэвэр хөрөнгө/өмч” гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. НББОУС 8 дахь адилтгах нэр томъёо нь “орлогын тайлан”, “хуримтлагдсан ашиг” ба “өмч” юм.
- НББОУС 8-ийн хувьд “орлого” /revenue/ нэр томъёоноос илүү өргөн утгатай байдаг “орлого” /income/ нэр томъёог УСНББОУС 3-д ашигладаггүй.
- УСНББОУС 3 нь НББОУС 8 (7-р параграф)-д зааснаас өөр, техникийн нэр томъёоны цогц тодорхойлолтыг агуулсан байдаг.
- УСНББОУС 3 нь НББОУС 8-тай ижил шатлал, эрэмбэтэй байдаг.
- УСНББОУС 3 нь нэгж хувьцаанд ногдох суурь буюу хорогдуулсан ашгийн тохируулгын талаар тодруулга хийхийг шаарддаггүй. НББОУС 8 нь нэгж хувьцаанд ногдох суурь буюу хорогдуулсан ашгийн тохируулга эсвэл засварлалтын дүнгийн талаар тодруулга хийхийг шаарддаг.

## УСНББОУС 4-ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨ

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) 21, *Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө* (2003 онд хянан засварласан хувилбарт 2005 онд нэмэлт өөрчлөлт оруулсан)-нөөс үндсэндээ бэлтгэсэн болно. НББОУС 21-ээс авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон EC4M 6XH, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)  
Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.

## УСНББОУС 4-ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨ

### УСНББОУС-ын түүх

Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

УСНББОУС 4, Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө-г 2000 оны 5 дугаар сард гаргасан.

2006 оны 12 дугаар сард УСНББОУСЗ нь хянан засварласан УСНББОУС 4-ийг гаргасан.

2008 оны 4 дүгээр сард УСНББОУСЗ нь хянан засварласан УСНББОУС 4-ийг гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 4-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 37, Хамтын Хэлэлцээр (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 35, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2011-ийн Сайжруулалтууд (2011 оны 10 дугаар сард гаргасан)
- УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба Хэмжилт (2010 оны 01 дүгээр сард гаргасан)

### УСНББОУС 4-ийн нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт

Өөрчлөгдсөн параграф	Хэрхэн өөрчилсөн	Юугаар өөрчилсөн
Танилцуулга хэсэг	Хассан	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
3	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар УСНББОУС 29, 2010 оны 01-р сар
4	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 29, 2010 оны 01-р сар
5	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 29, 2010 оны 01-р сар
6	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
7	Хассан	УСНББОУС 28, 2010 оны 01-р сар
10	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар

ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨ

13	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар
21	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар
22	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
31	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 29, 2010 оны 01-р сар
38	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар
47	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
50	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар
51	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
53	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
55	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
57	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар
57А	Шинэ	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар
57Б	Шинэ	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар
57В	Шинэ	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар
57Г	Шинэ	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар
58	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар
61	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 29, 2010 оны 01-р сар
67	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
68	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
69	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
70	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
71А	Шинэ	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
71Б	Шинэ	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
71В	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
72	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар

2008 оны 4 дүгээр сар

## УСНББОУС 4–ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨ

### АГУУЛГА

	Параграф
Зорилго	1-2
Цар хүрээ	3-9
Тодорхойлолт	10-19
Бүртгэлийн валют	11-16
Мөнгөн зүйлс	17
Гадаад үйл ажиллагаан дахь цэвэр хөрөнгө оруулалт	18-19
Энэ Стандартаар шаардсан арга хандлагын тойм	20-22
Гадаад валютаарх ажил гүйлгээг бүртгэлийн валютаар тайлагнах	23-42
Анхны хүлээн зөвшөөрөлт	23-26
Дараагийн тайлант үеүдийн эцэс дэх тайлагнал	27-30
Ханшийн зөрүүгийн хүлээн зөвшөөрөлт	31-39
Бүртгэлийн валютын өөрчлөлт	40-42
Бүртгэлийн валютаас өөр валютыг толилуулгад ашиглах	43-58
Толилуулгын валютад хөрвүүлэлт	43-49
Гадаад үйл ажиллагааны хөрвүүлэлт	50-56
Гадаад үйл ажиллагааны бүрэн буюу хэсэгчилсэн данснаас хасалт	57-58
Ханшийн зөрүүгийн татварын үр нөлөө	59
Тодруулга	60-66
Шилжилтийн нөхцөл	67-70
Аккруэл нягтлан бодох бүртгэлийг анх удаа мөрдөх	67-68
Бүх байгууллагуудад зориулсан шилжилтийн нөхцлүүд	69-70
Хүчин төгөлдөр болох хугацаа	71-72
УСНББОУС 4 (2006)-өөс татгалзах	73
Дүгнэлтийн үндэслэл	
Харьцуулах хүснэгт	
НББОУС 21-тэй харьцуулалт	



## ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨ

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 4, *Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө*-г 1-73-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 4-ийг түүний зорилгын агуулга, Дүгнэлтийн Үндэслэл, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

1. Байгууллага нь ажил гүйлгээг гадаад валютаар хийх эсвэл гадаадад үйл ажиллагаа явуулах гэсэн хоёр арга замаар гадаад үйл ажиллагааг эрхэлж болох юм. Түүнчлэн, байгууллага нь өөрийн санхүүгийн тайлангаа гадаад валютаар толилуулж болно. Энэхүү Стандартын зорилго нь гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээ ба гадаад дахь үйл ажиллагааг тухайн байгууллагын санхүүгийн тайланд хэрхэн тусгах болон санхүүгийн тайланг толилуулгын валютанд хэрхэн хөрвүүлэхийг тодорхойлоход оршино.
2. Үндсэн асуудал нь (а) валютын ямар ханш хэрэглэх, ба (а) валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөөг санхүүгийн тайланд хэрхэн тусгах явдал юм.

## Цар хүрээ

3. **Нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь энэ Стандартыг дараах тохиолдолд мөрдөнө:**
  - (а) **УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт-ийн цар хүрээнд хамаарах үүсмэл хэрэглүүрийн ажил гүйлгээ ба түүний үлдэгдлээс бусад гадаад валютаар гарсан ажил гүйлгээ болон үлдэгдлийг тайлагнахад;**
  - (б) **Нэгтгэл буюу өмчийн аргын дагуу тухайн байгууллагын санхүүгийн тайланд тусган оруулсан гадаад дахь үйл ажиллагааны санхүүгийн үр дүн болон санхүүгийн байдлыг хөрвүүлэхэд;**
  - (в) **Байгууллагын санхүүгийн үр дүн болон санхүүгийн байдлыг толилуулгын валютанд хөрвүүлэхэд.**
4. Гадаад валютаарх маш олон үүсмэл хэрэглүүрийн хувьд УСНББОУС 29-ийг мөрддөг тул тэдгээрийг энэ Стандартын цар хүрээнд хамруулаагүй. Харин УСНББОУС 29-ийн цар хүрээнд хамаардаггүй, гадаад валютаарх үүсмэл хэрэглүүрүүд (жишээлбэл; өөр гэрээнүүдийг дагалдах гадаад валютаарх зарим үүсмэл хэрэглүүр) нь энэ Стандартын цар хүрээнд хамаарна. Түүнчлэн, байгууллага нь үүсмэл хэрэглүүрт хамаарах дүнгүүдийг өөрийн бүртгэлийн валютаас толилуулгын валютанд хөрвүүлэхдээ энэхүү Стандартыг даган мөрдөнө.
5. Гадаад валютаарх зүйлсийн хейжийн нягтлан бодох бүртгэл, үүн дотроо гадаад үйл ажиллагааны цэвэр хөрөнгө оруулалтын хейжийн хувьд энэ Стандартыг мөрдөхгүй. Хейжийн нягтлан бодох бүртгэлийн хувьд УСНББОУС 29-ийг мөрдөнө.
6. [Хассан]
7. [Хассан]

8. Энэ Стандарт нь байгууллагын санхүүгийн тайланг гадаад валютаар толилуулахад мөрдөгдөх бөгөөд тэдгээр санхүүгийн тайланг УСНББОУС-тай нийцсэн гэж тодорхойлох шаардлагуудыг тогтоодог. Эдгээр шаардлагуудыг хангахгүй байдлаар санхүүгийн мэдээллийг гадаад валютанд хөрвүүлсэн тохиолдолд тодруулга хийвэл зохих мэдээллийг энэ Стандартанд тусгайлан заасан байдаг.
9. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээнээс үүссэн мөнгөн гүйлгээг мөнгөн гүйлгээний тайланд толилуулах эсвэл гадаад үйл ажиллагаанаас үүссэн мөнгөн гүйлгээг хөрвүүлэхэд энэ Стандартыг дагаж мөрдөхгүй (УСНББОУС 2, *Мөнгөн Гүйлгээний Тайланг*-г үзнэ үү).

## Тодорхойлолт

10. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

**Хаалтын ханш** гэдэг нь тайлант үеийн эцэс дэх спот ханш юм.

**Ханшийн зөрүү** гэдэг нь тодорхой тооны нэг валютыг нөгөө валютанд өөр өөр ханшаар хөрвүүлснээс үүссэн зөрүү юм.

**Валютын ханш** гэдэг нь хоёр валютын хоорондох солилцооны харьцаа юм.

**Гадаад валют** гэдэг нь байгууллагын бүртгэлийн валютаас өөр валют юм.

**Гадаад үйл ажиллагаа** гэдэг нь тайлагнагч байгууллагын улс орон буюу валютаас өөр улс орон буюу валютанд үндэслэн үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг уг тайлагнагч байгууллагын хяналтанд буй байгууллага, хараат компани, хамтын хэлэлцээр эсвэл салбар юм.

**Бүртгэлийн валют** гэдэг нь тухайн байгууллага үйл ажиллагаагаа явуулдаг эдийн засгийн анхдагч орчны валют юм.

**Мөнгөн зүйлс** гэдэг нь эзэмшиж буй мөнгөн нэгжүүд, түүнчлэн тогтмол буюу тодорхойлж болох мөнгөн нэгжээр хүлээн авах хөрөнгө ба төлөх өр төлбөр юм.

**Гадаад үйл ажиллагааны цэвэр хөрөнгө оруулалт** гэдэг нь тухайн гадаад үйл ажиллагааны цэвэр хөрөнгө/өмчид уг тайлагнагч байгууллагын эзэмших хувь оролцооны дүн юм.

**Толилуулгын валют** гэдэг нь тухайн санхүүгийн тайланг толилуулдаг валют юм.

**Спот ханш** гэдэг нь тэр даруй хийгдэх солилцоонд хамаарах валютын ханш юм.

**Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д дахин нийтэлсэн болно.**

### **Бүртгэлийн валют**

11. Байгууллага үйл ажиллагаагаа явуулдаг эдийн засгийн анхдагч орчин нь үндсэндээ мөнгөн хөрөнгө бий болгож, зарцуулдаг орчин юм. Байгууллага нь өөрийн бүртгэлийн валютыг тодорхойлохдоо дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ:
  - (a) Валют:
    - (i) энэ нь татвар, буцалтгүй тусламж, алданги гэх мэт орлого үүсдэг валют юм;
    - (ii) бараа, үйлчилгээний борлуулалтын үнэд голчлон нөлөөлдөг валют (энэ нь түүний бараа, үйлчилгээний борлуулалтын үнийг ихэвчлэн илэрхийлж, төлбөрийг хүлээн авдаг валют юм); ба
    - (iii) энэ нь өрсөлдөөний хүч болон зохицуулалтаараа түүний бараа, үйлчилгээний борлуулалтын үнийг голчлон тодорхойлдог улсын валют юм.
  - (б) Бараа, үйлчилгээг нийлүүлэхэд гардаг хөдөлмөр, материал болон бусад зардалд голчлон нөлөөлдөг валют (энэ нь ийм зардлуудыг ихэвчлэн илэрхийлж, барагдуулдаг валют байна).
12. Дараах хүчин зүйлс нь байгууллагын бүртгэлийн валютын талаархи нотолгоогоор бас хангаж болох юм:
  - (a) Санхүүгийн үйл ажиллагаанаас (өөрөөр хэлбэл, өрийн болон өмчийн хэрэглүүрийн гаргалтаас) бий болсон мөнгө сангийн илэрхийлэгдэх валют.
  - (б) Үндсэн үйл ажиллагаанаас бий болсон мөнгөн орлогыг ихэвчлэн хүлээн авдаг валют.
13. Гадаад үйл ажиллагааны бүртгэлийн валют, түүнчлэн уг валют нь тухайн тайлагнагч байгууллагын бүртгэлийн валюттай ижил эсэхийг тодорхойлохдоо дараах нэмэлт хүчин зүйлсийг мөн харгалзан үзнэ (энэ тохиолдолд тайлагнагч байгууллага гэдэг нь өөрийн хяналтанд буй байгууллага, салбар, хараат компани эсвэл хамтын хэлэлцээр байдлаар гадаад үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага байна):
  - (a) Гадаад үйл ажиллагааг тухайн тайлагнагч байгууллагын үйл ажиллагааны өргөжилт байдлаар эсвэл нилээд бие даасан байдлаар эрхлэн явуулдаг эсэх. Тайлагнагч байгууллагын өргөжилт байдлаар явуулдаг үйл ажиллагааны жишээ нь; батлан хамгаалах яам үндэсний засгийн газрын нэрийн өмнөөс гадаад орнуудад үйл ажиллагаагаа явуулдаг олон баазтай байх тохиолдол юм. Батлан

## ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨ

хамгаалах яамны баазууд нь өөрсдийн үйл ажиллагааг үндсэндээ тухайн тайлагнагч байгууллагын бүртгэлийн валютаар эрхлэн явуулдаг байж болох юм. Жишээлбэл; цэргийн албан хаагч нь цалингаа бүртгэлийн валютаар авдаг бөгөөд багахан хэмжээний амьжиргааны зардлын мөнгийг орон нутгийн валютаар авдаг байж болно. Орон нутгийн валютаар хийх худалдан авалтыг хамгийн бага болгосноор хангамжийн зүйлс болон тоног төхөөрөмжийг ихэнхдээ тухайн тайлагнагч байгууллагаар дамжуулан худалдан авдаг байж болно. Өөр нэг жишээ нь улсын их сургуулийн дотоодын сургалтын албаны удирдлага ба хяналтан дор үйл ажиллагаагаа явуулдаг гадаад дахь сургалтын төвүүд юм. Харин эсрэгээр, нилээд бие даасан байдалтай гадаад үйл ажиллагаа нь мөнгө ба бусад мөнгөн зүйлсийг хуримтлуулах, зардал гаргах, орлого олох, түүнчлэн зээл авах гэх мэт бараг бүх үйл ажиллагааг өөрийн орон нутгийн валютаар гүйцэтгэдэг байж болно. Засгийн газрын бусад агентлагуудаас хараат бусаар үйл ажиллагаагаа явуулдаг засгийн газрын өмчлөлт гадаад үйл ажиллагааны зарим жишээнд аялал жуулчлалын алба, газрын тосны хайгуулын компани, худалдааны зөвлөл, радио телевизийн үйл ажиллагаа хамаарч болох юм. Ийм байгууллагуудыг улсын секторын худалдаа арилжааны байгууллага байдлаар зохион байгуулж болно.

- (б) Тайлагнагч байгууллагатай гадаад үйл ажиллагааны хийсэн ажил гүйлгээ нь тухайн гадаад үйл ажиллагааны хувьд их эсвэл бага хувийн жинг эзэлж буй эсэх.
- (в) Гадаад үйл ажиллагаанаас бий болсон мөнгөн гүйлгээ нь тухайн тайлагнагч байгууллагын мөнгөн гүйлгээнд шууд нөлөөлдөг эсэх, мөн түүний мөнгийг уг тайлагнагч байгууллагад шууд шилжүүлэх боломжтой эсэх.
- (г) Гадаад үйл ажиллагаанаас бий болсон мөнгөн гүйлгээ нь одоо байгаа бөгөөд хэвийн байдлаар төлөхөөр хүлээгдэж буй өр төлбөрийг, уг тайлагнагч байгууллагаас мөнгө хөрөнгө авахгүйгээр барагдуулахад хүрэлцээтэй эсэх.

- 14. Дээрх үзүүлэлтүүд холилдон нийлсэн бөгөөд бүртгэлийн валют нь илт тодорхой биш байх тохиолдолд удирдлага нь уг суурь ажил гүйлгээ, үйл явдал, нөхцөл байдлын эдийн засгийн үр нөлөөг хамгийн үнэн зөв илэрхийлэх бүртгэлийн валютыг тодорхойлохын тулд өөрийн шүүн тунгаалтыг хийдэг. Энэ арга хандлагын нэг хэсэг болгон байгууллагын бүртгэлийн валютыг тодорхойлохдоо удирдлага нь нэмэлт дэмжих нотолгоогоор хангахад чиглэгдсэн 12, 13-р параграфт дурдсан үзүүлэлтүүдийг авч үзэхийн өмнө 11-р параграфт заасан, анхдагч үзүүлэлтүүдэд юуны өмнө ач холбогдол өгнө.
- 15. Байгууллагын бүртгэлийн валют нь тухайн байгууллагад хамааралтай суурь ажил гүйлгээ, үйл явдал, нөхцөл байдлыг тусгадаг. Иймээс бүртгэлийн валютыг нэгэнт тодорхойлсон тохиолдолд хэрэв суурь ажил гүйлгээ, үйл явдал, нөхцөл байдалд өөрчлөлт ороогүй л бол бүртгэлийн валютыг өөрчлөхгүй.

16. Хэрэв бүртгэлийн валют нь хэт инфляцитай эдийн засгийн валют бол тухайн байгууллагын санхүүгийн тайланг УСНББОУС 10, *Хэт Инфляцитай Эдийн Засгийн Үеийн Санхүүгийн Тайлагнал*-ын дагуу дахин тайлагнана. Байгууллага нь тухайлбал, энэхүү Стандартын дагуу тодорхойлсон бүртгэлийн валютаас өөр валютыг (түүний хяналт тавигч байгууллагын бүртгэлийн валют гэх мэт) өөрийн бүртгэлийн валют гэж сонгон хэрэглэснээр УСНББОУС 10-ын дагуу хийх дахин тайлагналаас зайлсхийж болохгүй юм.

### **Мөнгөн зүйлс**

17. Мөнгөн зүйлсийн гол шинж нь тогтмол буюу тодорхойлж болох мөнгөн нэгжийг хүлээн авах эрх (эсвэл нийлүүлэн өгөх үүрэг) юм. Жишээлбэл; мөнгөөр төлөгдөх нийгмийн бодлогын үүрэг ба ажилтны бусад тэтгэмж; мөнгөөр төлөгдөх нөөц сан; өр төлбөр гэж хүлээн зөвшөөрсөн мөнгөн ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт. Харин эсрэгээр, мөнгөн бус зүйлсийн гол шинж нь тогтмол буюу тодорхойлж болох мөнгөн нэгжээр хүлээн авах эрх (эсвэл нийлүүлэн өгөх үүрэг) байдаггүй явдал юм. Жишээлбэл; бараа, үйлчилгээний хувьд урьдчилж төлсөн дүн (тухайлбал, урьдчилж төлсөн түрээс); гүүдвил; биет бус хөрөнгө; бараа материал; үндсэн хөрөнгө; мөнгөн зүйлсийн бус хөрөнгө нийлүүлсэнээр барагдуулдаг нөөц сан.

### **Гадаад үйл ажиллагаан дахь цэвэр хөрөнгө оруулалт**

18. Байгууллага нь гадаад үйл ажиллагаанаас авах авлага эсвэл түүнд төлөх өглөгийг илэрхийлэх мөнгөн зүйлстэй байж болно. Төлөлт хийгдэхээр төлөвлөгдөөгүй, түүнчлэн ойрын ирээдүйд төлөлт хийгдэх магадлал багатай зүйлс нь мөн чанарын хувьд тухайн гадаад үйл ажиллагаанд оруулсан уг байгууллагын цэвэр хөрөнгө оруулалтын нэг хэсэг болох бөгөөд үүнийг 37, 38-р параграфын дагуу тайлагнана. Ийм мөнгөн зүйлсэд урт хугацаат авлага буюу зээлийг оруулж болох юм. Харин дансны авлага эсвэл дансны өглөг үүнд хамаарахгүй.
19. 18-р параграфт заасанчлан, гадаад үйл ажиллагаанаас авах авлага эсвэл түүнд төлөх өглөгтэй байгууллага нь өөрөө уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын ямар нэг хяналтанд буй байгууллага байж болох юм. Жишээлбэл; байгууллага нь өөрийн хяналтанд буй А ба Б гэсэн хоёр байгууллагатай. Хяналтанд буй Б байгууллага нь гадаад үйл ажиллагаа юм. Харин хяналтанд буй А байгууллага нь хяналтанд буй Б байгууллагад зээл олгосон. Уг зээлийг төлөхөөр төлөвлөөгүй, түүнчлэн ойрын ирээдүйд төлөгдөх магадлал багатай бол хяналтанд буй Б байгууллагаас хяналтанд буй А байгууллагын авах зээлийн авлага нь тухайн хяналтанд буй Б байгууллагад А байгууллагын оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын нэг хэсэг болно. Хяналтанд буй А байгууллага нь өөрөө гадаад үйл ажиллагаа байсан ч гэсэн энэ нөхцөл мөн адил үнэн байх юм.

**Энэ Стандартаар шаардсан арга хандлагын тойм**

20. Бие даасан дан ганц байгууллага, гадаад үйл ажиллагаа бүхий байгууллага (хяналт тавигч байгууллага гэх мэт) эсвэл гадаад үйл ажиллагаа (хяналтанд буй байгууллага эсвэл салбар гэх мэт) эсэхээс үл хамааран байгууллага бүр нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ өөрийн бүртгэлийн валютыг 11-16-р параграфын дагуу тодорхойлно. Байгууллага нь гадаад валютаар гарсан зүйлсийг өөрийн бүртгэлийн валютанд хөрвүүлж, энэхүү хөрвүүлэлтийн үр нөлөөг 23-42 ба 59-р параграфын дагуу тайлагнана.
21. Тайлагнагч олон байгууллага нь бие даасан олон байгууллагуудаас бүрддэг (жишээлбэл; эдийн засгийн нэгдмэл байгууллага нь хяналт тавигч байгууллага ба хяналтанд буй нэг буюу хэд хэдэн байгууллагуудаас бүрдэнэ). Эдийн засгийн нэгдмэл байгууллагын гишүүн эсэхээс үл хамааран янз бүрийн хэлбэрийн байгууллагууд нь хараат байгууллага эсвэл хамтын хэлэлцээрт хийсэн хөрөнгө оруулалттай байж болно. Мөн салбаруудтай байж болно. Тайлагнагч байгууллагад багтдаг бие даасан байгууллага нэг бүрийн санхүүгийн үр дүн болон санхүүгийн байдлыг тухайн тайлагнагч байгууллагын санхүүгийн тайлангаа толилуулдаг валютанд хөрвүүлэх шаардлагатай байдаг. Тайлагнагч байгууллагын толилуулгын валют нь ямар ч валют (эсвэл валютууд) байж болохыг энэхүү Стандартаар зөвшөөрдөг. Тухайн тайлагнагч байгууллагын хүрэн дэх аливаа бие даасан байгууллагын бүртгэлийн валют нь толилуулгын валютаас өөр байх тохиолдолд түүний санхүүгийн үр дүн болон санхүүгийн байдлыг 43-59-р параграфын дагуу хөрвүүлнэ.
22. Санхүүгийн тайлангаа бэлтгэж буй бие даасан дан ганц байгууллага эсвэл УСНББОУС 34, *Тусдаа Санхүүгийн Тайлан*-гийн дагуу тусдаа санхүүгийн тайлангаа бэлтгэж буй байгууллага нь өөрийн санхүүгийн тайланг ямар нэг дурын валют (эсвэл валютууд)-аар толилуулахыг энэхүү Стандартаар зөвшөөрдөг. Хэрэв байгууллагын толилуулгын валют нь түүний бүртгэлийн валютаас өөр бол уг байгууллагын санхүүгийн үр дүн болон санхүүгийн байдлыг 43-59-р параграфын дагуу толилуулгын валютанд бас хөрвүүлнэ.

**Гадаад валютаарх ажил гүйлгээг бүртгэлийн валютаар тайлагнах**

**Анхны хүлээн зөвшөөрөлт**

23. Гадаад валютаарх ажил гүйлгээ нь гадаад валютаар хийгдсэн эсвэл гадаад валютаар төлбөр тооцоог барагдуулахыг шаарддаг ажил гүйлгээ бөгөөд байгууллагын доорх ажил гүйлгээ хамаарна:
  - (а) Гадаад валютаар үнэ нь илэрхийлэгдсэн бараа, үйлчилгээг худалдан авах эсвэл худалдах;
  - (б) Өглөг, авлагын дүн нь гадаад валютаар илэрхийлэгдэх тохиолдолд мөнгө санг зээлдэн авах эсвэл зээл олгох;

- (в) Гадаад валютаар илэрхийлэгдэх бөгөөд дээр дурдсанаас өөр бусад байдлаар хөрөнгийг олж эзэмших буюу данснаас хасах, өр төлбөр үүсгэх буюу барагдуулах.
24. **Байгууллага нь гадаад валютаар гарсан ажил гүйлгээг анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн бүртгэлийн валют ба гадаад валютын хоорондох спот ханшаар уг гадаад валютын дүнг үржүүлж, бүртгэлийн валютаар бүртгэнэ.**
25. Ажил гүйлгээ гарсан өдөр гэдэг нь тухайн ажил гүйлгээг УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрөх шалгуурыг анх хангасан өдөр юм. Практик учир шалтгааны улмаас тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн бодит ханштай ойролцоо байх ханшийг ихэвчлэн ашигладаг. Жишээлбэл; тухайн тайлант үеийн туршид гадаад валют нэг бүрээр гарсан бүх ажил гүйлгээний хувьд долоо хоног эсвэл сарын дундаж ханшийг ашиглаж болно. Гэвч ханш ихээхэн хэлбэлзэлтэй байвал тухайн тайлант үеийн дундаж ханшийг ашиглах нь тохиромжгүй байдаг.
26. Гадаад валютын ханшийн өөрчлөлт нь гадаад валютаар эзэмшиж буй эсвэл гадаад валютаар төлөх мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгөнд нөлөө үзүүлж болох юм. Ийм ханшийн зөрүүгийн толилуулгыг УСНББОУС 2-д авч үздэг. Хэдийгээр ийм өөрчлөлт нь мөнгөн гүйлгээ биш боловч тухайн тайлант үеийн эхэн ба эцэс дэх мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг тохируулахын тулд гадаад валютаар эзэмшиж буй эсвэл гадаад валютаар төлөх мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгөнд үзүүлэх валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөөг мөнгөн гүйлгээний тайланд тайлагнадаг. Энэхүү дүнг үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны, санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээнээс тусдаа толилуулах бөгөөд тэдгээр мөнгөн гүйлгээг тухайн тайлант үеийн эцсийн ханшаар тайлагнасан бол аливаа зөрүүг түүнд багтаасан байна.

#### **Дараагийн тайлант үеүдийн эцэс дэх тайлагнал**

27. **Тайлант үе бүрийн эцэст:**
- (а) **Гадаад валютаарх мөнгөн зүйлсийг хаалтын ханшаар хөрвүүлэх;**
- (б) **Гадаад валютаарх түүхэн өртгөөрөө хэмжсэн мөнгөн бус зүйлсийг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн валютын ханшийг ашиглан хөрвүүлнэ; ба**
- (в) **Гадаад валютаарх бодит үнэ цэнээр хэмжсэн мөнгөн бус зүйлсийг уг бодит үнэ цэнийг хэмжсэн өдрийн валютын ханшийг ашиглан хөрвүүлнэ.**
28. Аль нэг зүйлийн дансны үнийг бусад хамаарах Стандартуудтай уялдуулан тодорхойлдог. Жишээлбэл; үндсэн хөрөнгийг УСНББОУС 17, *Үндсэн Хөрөнгө*-ийн дагуу бодит үнэ цэнээр эсвэл түүхэн өртгөөр хэмжиж болно. Дансны үнийг түүхэн өртөгт эсвэл бодит үнэ цэнэд үндэслэн тодорхойлсон эсэхээс үл хамааран хэрэв дүнг гадаад валютаар



## ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨ

илэрхийлсэн бол энэхүү Стандартын дагуу бүртгэлийн валютанд хөрвүүлнэ.

29. Зарим зүйлсийн дансны үнийг хоёр буюу хэд хэдэн дүнгүүдийг харьцуулах замаар тодорхойлдог. Жишээлбэл; борлуулах зорилгоор эзэмшиж буй бараа материалын дансны үнэ нь УСНББОУС 12, *Бараа Материал*-д заасанчлан, өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль бага нь байдаг. Үүнтэй адилаар, үнэ цэнийн бууралтын илрэл байгаа тохиолдолд УСНББОУС 21, *Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-ын дагуу уг мөнгө бий болгодоггүй хөрөнгийн дансны үнийг тухайн үнэ цэнийн бууралтын боломжит гарзын өмнөх түүний дансны үнэ ба нөхөгдөх дүнгийн аль багаар тодорхойлдог. Ийм хөрөнгө нь мөнгөн зүйлийн бус хөрөнгө бөгөөд түүнийг гадаад валютаар хэмжсэн тохиолдолд доорх зүйлсийг харьцуулснаар дансны үнийг тодорхойлно:

- (а) Тухайн дүнг тодорхойлсон өдрийн валютын ханш (өөрөөр хэлбэл, түүхэн өртгөөр хэмжсэн зүйлийн хувьд ажил гүйлгээ гарсан өдрийн ханш)-аар хөрвүүлсэн өртөг эсвэл дансны үнийн аль тохиромжтой нь; ба
- (б) Тухайн үнэ цэнийг тодорхойлсон өдрийн валютын ханш (жишээлбэл; тайлант үеийн эцэс дэх хаалтын ханш)-аар хөрвүүлсэн цэвэр боломжит үнэ цэнэ эсвэл нөхөгдөх дүнгийн аль тохиромжтой нь.

Энэхүү харьцуулалтын үр нөлөө нь бүртгэлийн валютаар хүлээн зөвшөөрөх боловч гадаад валютаар үл хүлээн зөвшөөрөх үнэ цэнийн бууралтын гарз байж болно. Эсвэл эсрэгээр, гадаад валютаар хүлээн зөвшөөрөх боловч бүртгэлийн валютаар үл хүлээн зөвшөөрөх гарз байж болох юм.

30. Валютын хэд хэдэн ханшийг ашиглах боломжтой тохиолдолд ашиглах ханш нь ирээдүйн мөнгөн гүйлгээг тухайн ажил гүйлгээгээр илэрхийлэх ханш, хэрэв тэдгээр мөнгөн гүйлгээ нь хэмжилтийн өдөр гарч тохиолдсон бол үлдэгдлийг барагдуулж болох ханш байна. Хэрэв хоёр валютыг хооронд нь солилцох боломжит байдал түр хугацаагаар алдагдвал ингэж солилцож болох дараагийн хамгийн эхний ханшийг ашиглана.

### **Ханшийн зөрүүгийн хүлээн зөвшөөрөлт**

31. 5-р параграфт дурдсанчлан, гадаад валютын зүйлсийн хейжийн нягтлан бодох бүртгэлд энэхүү Стандартыг мөрдөхгүй. Хейжийн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой заавар удирдамж, үүн дотроо хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэзээ ашиглах талаархи шалгуурыг УСНББОУС 29-өөс үзэж болно.

32. **37-р параграфт зааснаас бусад тохиолдолд, (а) мөнгөн зүйлсийн барагдуулалтаас, эсвэл (б) мөнгөн зүйлсийг тухайн тайлант үеийн туршид буюу өмнөх санхүүгийн тайланд анх хүлээн зөвшөөрөхдөө хөрвүүлсэн ханшаас өөр ханшаар хөрвүүлснээс үүссэн ханшийн**

**зөрүүг тэдгээрийн гарсан уг тайлант үеийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.**

33. Мөнгөн зүйлс нь гадаад валютаарх ажил гүйлгээнээс үүссэн бөгөөд уг ажил гүйлгээний өдөр ба барагдуулалтын өдрийн хооронд ханш өөрчлөгдсөн бол ханшийн зөрүү үүсдэг. Ажил гүйлгээ гарч тохиолдсон тухайн нэг нягтлан бодох бүртгэлийн тайлант үед түүний төлбөрийг барагдуулсан тохиолдолд бүх ханшийн зөрүүг уг тайлант үед хүлээн зөвшөөрнө. Харин ажил гүйлгээний төлбөрийг нягтлан бодох бүртгэлийн дараагийн тайлант үед барагдуулсан бол уг барагдуулалтын өдөр хүртэлх тайлант үе бүрд хүлээн зөвшөөрөх ханшийн зөрүү нь тэрхүү тайлант үе бүрийн валютын ханшийн өөрчлөлтөөр тодорхойлогдоно.
34. Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн мөнгөн гүйлгээний тайлан дахь тайлагналын арга хандлагыг 26-р параграфт заасан.
35. **Мөнгөн бус зүйлсийн олз, гарзыг цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрдөг тохиолдолд тэрхүү олз, гарзын ханшийн өөрчлөлттэй холбоотой аливаа бүрэлдэхүүн хэсгийг мөн цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрнө. Харин эсрэгээр, мөнгөн бус зүйлсийн олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг тохиолдолд тэрхүү олз, гарзын ханшийн өөрчлөлттэй холбоотой аливаа бүрэлдэхүүн хэсгийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.**
36. Бусад УСНББОУС нь зарим олз, гарзыг цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрөхийг шаарддаг. Жишээлбэл; УСНББОУС 17 нь үндсэн хөрөнгийн дахин үнэлгээнээс үүссэн зарим олз, гарзыг цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрөхийг шаарддаг. Ийм хөрөнгийг гадаад валютаар хэмждэг тохиолдолд үнэ цэнийг тодорхойлсон өдрийн ханшийг ашиглан уг дахин үнэлсэн дүнг хөрвүүлэх ба үр дүнгийн ханшийн зөрүүг мөн цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрөхийг энэ Стандартын 27(в) параграфтаар шаардсан байдаг.
37. Гадаад үйл ажиллагаан дахь уг тайлагнагч байгууллагын цэвэр хөрөнгө оруулалтын нэг хэсгийг бүрдүүлж байгаа мөнгөн зүйлсээс үүссэн валютын ханшийн зөрүүг (18-р параграфыг үзнэ үү) тухайн тайлагнагч байгууллагын тусдаа санхүүгийн тайлан эсвэл гадаад үйл ажиллагааны бие даасан санхүүгийн тайлангийн аль тохиромжтойд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Гадаад үйл ажиллагаа болон тухайн тайлагнагч байгууллагыг багтаасан санхүүгийн тайланд (жишээлбэл; гадаад үйл ажиллагаа нь хяналтанд буй байгууллага байх тохиолдолд нэгтгэсэн санхүүгийн тайланд) ийм ханшийн зөрүүг эхлээд цэвэр хөрөнгө/өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэсэгт хүлээн зөвшөөрөх бөгөөд дараа нь 57-р параграфын дагуу уг цэвэр хөрөнгө оруулалтын данснаас хасалтын ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.
38. Мөнгөн зүйлс нь гадаад үйл ажиллагаан дахь уг тайлагнагч байгууллагын цэвэр хөрөнгө оруулалтын нэг хэсгийг бүрдүүлэх ба тайлагнагч байгууллагын бүртгэлийн валютаар илэрхийлэгдсэн тохиолдолд 32-р

параграфт заасанчлан, ханшийн зөрүү нь тухайн гадаад үйл ажиллагааны бие даасан санхүүгийн тайланд үүснэ. Хэрэв ийм мөнгөн зүйлийг тухайн гадаад үйл ажиллагааны бүртгэлийн валютаар илэрхийлдэг бол ханшийн зөрүү нь 32-р параграфын дагуу уг тайлагнагч байгууллагын тусдаа санхүүгийн тайланд үүснэ. Хэрэв ийм мөнгөн зүйлийг тухайн тайлагнагч байгууллага эсвэл гадаад үйл ажиллагааны аль алины бүртгэлийн валютаас өөр валютаар илэрхийлсэн бол ханшийн зөрүү нь 32-р параграфын дагуу уг тайлагнагч байгууллагын тусдаа санхүүгийн тайланд болон гадаад үйл ажиллагааны бие даасан санхүүгийн тайланд үүснэ. Гадаад үйл ажиллагаа болон тухайн тайлагнагч байгууллагыг багтаасан санхүүгийн тайланд (өөрөөр хэлбэл, гадаад үйл ажиллагааг нэгтгэсэн буюу өмчийн аргыг ашиглан тайлагнасан санхүүгийн тайланд) ийм ханшийн зөрүүг цэвэр хөрөнгө/өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэсэгт дахин ангилна.

39. Байгууллага нь өөрийн бүртгэлийн валютаас өөр валютаар данс, бүртгэлээ хөтөлдөг тохиолдолд тухайн байгууллага санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ бүх дүнгүүдийг 23-30-р параграфын дагуу бүртгэлийн валютанд хөрвүүлнэ. Ингэснээр мөнгөн болон мөнгөн бус зүйлсийг анх бүртгэлийн валютаар бүртгэсэн бол гарах байсантай ижил дүнг бүртгэлийн валютаар илэрхийлэх юм. Жишээлбэл; мөнгөн зүйлсийг хаалтын ханш ашиглан бүртгэлийн валютанд хөрвүүлнэ. Түүхэн өртгийн сууриар хэмжсэн мөнгөн бус зүйлсийг тэдгээрийн хүлээн зөвшөөрөлтөнд хүргэсэн уг ажил гүйлгээний өдрийн ханшаар хөрвүүлнэ.

#### **Бүртгэлийн валютын өөрчлөлт**

40. **Байгууллагын бүртгэлийн валют өөрчлөгдсөн тохиолдолд уг байгууллага нь шинэ бүртгэлийн валютын хувьд хэрэглэх хөрвүүлэлтийн горимоо тухайн өөрчлөлтийн өдрөөс эхлэн гүйцээх горимоор мөрдөнө.**
41. 15-р параграфт заасанчлан, байгууллагын бүртгэлийн валют нь тухайн байгууллагад хамааралтай суурь ажил гүйлгээ, үйл явдал, нөхцөл байдлыг тусгадаг. Иймээс бүртгэлийн валютыг тодорхойлсноос хойш тэдгээр суурь ажил гүйлгээ, үйл явдал, нөхцөл байдалд өөрчлөлт орсон зөвхөн тэр тохиолдолд бүртгэлийн валютыг өөрчилж болно. Жишээлбэл; бараа, үйлчилгээний борлуулалтын үнэ буюу нийлүүлэлтэнд ихэвчлэн нөлөөлдөг валютын өөрчлөлт нь уг байгууллагын бүртгэлийн валют өөрчлөгдөхөд хүргэж болох юм.
42. Бүртгэлийн валютын өөрчлөлтийн үр нөлөөг гүйцээх горимоор тайлагнана. Өөрөөр хэлбэл, байгууллага нь уг өөрчлөлтийн өдрийн валютын ханшийг ашиглан бүх зүйлсийг тэрхүү шинэ бүртгэлийн валютанд хөрвүүлдэг. Мөнгөн бус зүйлсийн хувьд хөрвүүлэн гаргасан дүнг түүний түүхэн өртөг гэж авч үзнэ. 37 ба 44(в) параграфын дагуу өмнө нь цэвэр хөрөнгө/өмчид ангилж байсан гадаад үйл ажиллагааны хөрвүүлэлтээс үүссэн ханшийн зөрүүг тухайн гадаад үйл ажиллагааг данснаас хасах хүртэл ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөхгүй.

## **Бүртгэлийн валютаас өөр валютыг толилуулгад ашиглах**

### **Толилуулгын валютад хөрвүүлэлт**

43. Байгууллага нь өөрийн санхүүгийн тайлангаа ямар ч валют (эсвэл валютууд)-аар толилуулж болох юм. Хэрэв уг толилуулгын валют нь байгууллагын бүртгэлийн валютаас өөр бол тухайн байгууллага нь өөрийн санхүүгийн үр дүн болон санхүүгийн байдлаа толилуулгын валютанд хөрвүүлнэ. Жишээлбэл; олон улсын байгууллага гэх мэт эдийн засгийн нэгдмэл байгууллага нь өөр өөр бүртгэлийн валют хэрэглэдэг бие даасан байгууллагуудаас бүрддэг тохиолдолд нэгтгэсэн санхүүгийн тайланг толилуулах боломжтой болохын тулд байгууллага тус бүрийн санхүүгийн үр дүн ба санхүүгийн байдлыг нэгэн ижил валютаар илэрхийлнэ. Үндэсний, мужийн/орон нутгийн засгийн газрын хувьд толилуулгын валютыг ихэвчлэн Сангийн яам (буюу адилтгах эрх бүхий байгууллага) тодорхойлдог буюу хууль тогтоомжинд заасан байдаг.
44. **Бүртгэлийн валют нь хэт инфляцитай эдийн засгийн үеийн валют биш байх тохиолдолд дараах горимуудыг ашиглан байгууллагын санхүүгийн үр дүн ба санхүүгийн байдлыг уг бүртгэлийн валютаас өөр байх толилуулгын валютанд хөрвүүлнэ:**
- (а) **Толилуулсан санхүүгийн байдлын тайлан тус бүрийн (өөрөөр хэлбэл, зэрэгцүүлсэн тайлангууд хамаарна) хувьд хөрөнгө ба өр төлбөрийг тухайн санхүүгийн байдлын тайлангийн өдрөөрх хаалтын ханшаар хөрвүүлнэ;**
  - (б) **Санхүүгийн үр дүнгийн тайлан тус бүрийн (өөрөөр хэлбэл, зэрэгцүүлсэн тайлангууд хамаарна) хувьд орлого, зардлыг тухайн ажил гүйлгээ гарсан өдрүүдийн ханшаар хөрвүүлнэ;**
  - (в) **Үр дүн болох бүх ханшийн зөрүүг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө.**
45. Мөнгөн гүйлгээг, өөрөөр хэлбэл, түүний мөнгөн гүйлгээний тайланд тусган оруулсан гадаад үйл ажиллагааны мөнгөн орлого ба мөнгөн төлбөрийг хөрвүүлэх үед уг тайлагнагч байгууллага нь УСНББОУС 2-д заасан горимыг мөрдөнө. Гадаад үйл ажиллагааны тодорхойлолтыг хангадаг, хяналтанд буй байгууллагын мөнгөн гүйлгээг тухайн мөнгөн гүйлгээ гарсан өдрийн толилуулгын валют ба гадаад валютын хоорондох ханшаар хөрвүүлэхийг УСНББОУС 2-оор шаардсан байдаг. Гадаад валютаар эзэмшиж буй эсвэл гадаад валютаар төлөх мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгөнд гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс үүсэх, хэрэгжээгүй олз, гарзын толилуулгыг УСНББОУС 2-д бас заасан.
46. Практик шалтгааны улмаас орлого, зардлын зүйлсийг хөрвүүлэхдээ тухайн ажил гүйлгээ гарсан өдрүүдийн валютын ханштай ойролцоо ханшийг, тухайлбал, тайлант үеийн дундаж ханшийг ихэвчлэн ашигладаг. Гэвч ханш ихээхэн хэлбэлзэлтэй байвал тухайн тайлант үеийн дундаж ханшийг ашиглах нь тохиромжгүй байдаг.

47. 44(в) параграфт дурдсан ханшийн зөрүү нь дараах зүйлсээс үүсдэг:

- (а) Орлого, зардлыг тухайн ажил гүйлгээ гарсан өдрүүдийн ханшаар, харин хөрөнгө, өр төлбөрийг хаалтын ханшаар хөрвүүлснээс үүснэ. Ийм ханшийн зөрүү нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн орлого, зардлын зүйлс болон цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн зүйлсийн аль алинаас үүсдэг.
- (б) Цэвэр хөрөнгө/өмчийн эхний үлдэгдлийг өмнөх хаалтын ханшаас өөр хаалтын ханшаар хөрвүүлснээс үүснэ.

Валютын ханшийн өөрчлөлтүүд нь үндсэн үйл ажиллагааны одоогийн болон ирээдүйн мөнгөн гүйлгээнд бага нөлөөтэй эсвэл шууд нөлөө үзүүлэхгүй тул эдгээр ханшийн зөрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөхгүй. Ханшийн зөрүү нь нэгтгэсэн боловч бүрэн өмчлөлт бус гадаад үйл ажиллагаатай холбоотой байх тохиолдолд хөрвүүлэлтээс үүссэн бөгөөд хяналтын бус хувь оролцоонд хамаарах ханшийн хуримтлагдсан зөрүүг тухайн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан дахь хяналтын бус хувь оролцоонд хуваарилж, түүний нэг хэсэг байдлаар хүлээн зөвшөөрнө.

48. **Бүртгэлийн валют нь хэт инфляцитай эдийн засгийн үеийн валют байх тохиолдолд дараах горимуудыг ашиглан тухайн байгууллагын санхүүгийн үр дүн ба санхүүгийн байдлыг уг бүртгэлийн валютаас өөр байх толилуулгын валютанд хөрвүүлнэ:**

- (а) Доорхоос бусад тохиолдолд бүх дүнгүүдийг (өөрөөр хэлбэл, хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн зүйлс, орлого, зардал, үүн дотроо зэрэгцүүлэгдэх дүнгүүд) хамгийн сүүлийн санхүүгийн байдлын тайлангийн өдрөөрх хаалтын ханшаар хөрвүүлнэ:
- (б) Дүнгүүдийг хэт инфляцитай биш эдийн засгийн валютанд хөрвүүлэх тохиолдолд зэрэгцүүлэгдэх дүнгүүд нь холбогдох өмнөх жилийн санхүүгийн тайланд тухайн тайлант жилийн дүн гэж толилуулсан тэдгээр дүнгүүд (өөрөөр хэлбэл, үнийн түвшний дараагийн өөрчлөлтүүд эсвэл валютын ханшийн дараагийн өөрчлөлтүүдийн хувьд тохируулга хийгээгүй) байна.

49. Байгууллагын бүртгэлийн валют нь хэт инфляцитай эдийн засгийн үеийн валют байх тохиолдолд 48-р параграфт заасан хөрвүүлэлтийн аргыг хэрэглэхийн өмнө уг байгууллага нь хэт инфляцитай биш эдийн засгийн үеийн валютаар хөрвүүлсэн зэрэгцүүлэгдэх дүнгүүдээс (48(б) параграфыг үзнэ үү) бусад дүнгүүдийн хувьд өөрийн санхүүгийн тайланг УСНББОУС 10-ын дагуу дахин илэрхийлнэ. Эдийн засгийн хэт инфляци зогсож, байгууллага өөрийн санхүүгийн тайланг УСНББОУС 10-ын дагуу дахин илэрхийлэхээ больсон тохиолдолд тухайн байгууллага нь өөрийн санхүүгийн тайланг ингэж дахин илэрхийлэхээ больсон өдрийн үнийн түвшнээр дахин илэрхийлсэн дүнгүүдийг түүхэн өртөг гэж үзэж, уг толилуулгын валютанд хөрвүүлэлт хийхэд ашиглана.

**Гадаад үйл ажиллагааны хөрвүүлэлт**

50. Гадаад үйл ажиллагааг нэгтгэл эсвэл өмчийн аргаар тухайн тайлагнагч байгууллагын санхүүгийн тайланд тусгах боломжтой болохын тулд уг гадаад үйл ажиллагааны санхүүгийн үр дүн ба санхүүгийн байдлыг толилуулгын валютанд хөрвүүлэх үед 43-49-р параграфас гадна 51-56-р параграфыг дагаж мөрдөнө.
51. Гадаад үйл ажиллагааны санхүүгийн үр дүн, санхүүгийн байдлыг тухайн тайлагнагч байгууллагын харгалзах үзүүлэлтүүдтэй нэгтгэн нийлүүлэхдээ, тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх хоорондын үлдэгдэл ба ажил гүйлгээг устгах гэх мэт нэгтгэлийн хэвийн горимуудыг баримтална (УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*-г-үзнэ үү).
52. Гэхдээ нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь валютын хэлбэлзлийн үр нөлөөг тусгахгүйгээр эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх богино буюу урт хугацаат мөнгөн зүйлсийн хөрөнгө (буюу өр төлбөр)-ийг тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх харгалзах өр төлбөр (буюу хөрөнгө)-тэй устган хааж болохгүй. Яагаад гэвэл, мөнгөн зүйлс нь (а) нэг валютыг нөгөө валютанд хөрвүүлэх хариуцлагыг илэрхийлдэг, ба (б) валютын хэлбэлзлийн улмаас уг тайлагнагч байгууллагад олз эсвэл гарз үүсдэг. Тиймээс энэхүү ханшийн зөрүүг тухайн тайлагнагч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд ашиг эсвэл алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Хэрэв ийм ханшийн зөрүү нь 37-р параграфт заасан нөхцөл байдлуудаас үүссэн бол уг гадаад үйл ажиллагааг данснаас хасах хүртэл түүнийг цэвэр хөрөнгө/өмч гэж ангилна.
53. Гадаад үйл ажиллагааны санхүүгийн тайлангийн огноо нь уг тайлагнагч байгууллагын санхүүгийн тайлангийн огнооноос өөр байх тохиолдолд уг гадаад үйл ажиллагаа нь тухайн тайлагнагч байгууллагын санхүүгийн тайлангийн огноотой ижил хугацаагаар нэмэлт тайланг ихэвчлэн бэлтгэдэг. Хяналт тавигч байгууллагын тайлант хугацаа нь уг хяналтанд буй байгууллагын тайлант хугацаанаас өөр байх тохиолдолд хамаарах шаардлагуудыг УСНББОУС 35-д тусгайлан заасан байдаг.
54. Тайлагнагч байгууллагын болон гадаад үйл ажиллагааны тайлангийн өдрүүд өөр байх тохиолдолд гадаад үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийг тухайн гадаад үйл ажиллагааны тайлант үеийн эцэс дэх валютын ханшаар хөрвүүлнэ.
55. Тайлагнагч байгууллагын тухайн тайлант үеийн эцэс хүртэл валютын ханшид гарсан мэдэгдэхүйц өөрчлөлтүүдийн хувьд УСНББОУС 35-ын дагуу тохируулга хийнэ. Хараат компани болон хамтарсан үйлдвэрийн хувьд УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*-ын дагуу өмчийн аргыг мөрдөхдөө энэхүү арга хандлагыг ашиглана.
56. **Гадаад үйл ажиллагааг олж эзэмших явцад үүссэн аливаа гүүдвилл ба уг гадаад үйл ажиллагааг олж эзэмших явцад үүссэн хөрөнгө, өр**

төлбөрийн дансны үнэд хийсэн бодит үнэ цэнийн аливаа тохируулгыг тухайн гадаад үйл ажиллагааны хөрөнгө ба өр төлбөр гэж үзнэ. Иймээс эдгээрийг уг гадаад үйл ажиллагааны бүртгэлийн валютаар илэрхийлэх бөгөөд 44, 48-р параграфын дагуу хаалтын ханшаар хөрвүүлнэ.

**Гадаад үйл ажиллагааны бүрэн буюу хэсэгчилсэн данснаас хасалт**

57. Гадаад үйл ажиллагааг данснаас хасах тохиолдолд тухайн гадаад үйл ажиллагаатай холбоотой бөгөөд цэвэр хөрөнгө/өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэсэгт хуримтлуулан бүртгэж байсан ханшийн зөрүүгийн хуримтлагдсан дүнг уг данснаас хасалтын олз, гарзыг хүлээн зөвшөөрсөн үед (УСНББОУС 1 Санхүүгийн Тайлангийн Толилуулга-ыг үзнэ үү) цэвэр хөрөнгө/өмчөөс ашиг, алдагдалд дахин ангилна.
- 57А. Гадаад үйл ажиллагаан дахь уг байгууллагын нийт хувь оролцооны данснаас хасалтаас гадна дараах хэсэгчилсэн данснаас хасалтыг мөн данснаас хасалт байдлаар тайлагнадаг. Үүнд:
- (а) Хэсэгчилсэн данснаас хасалтын дараа тухайн байгууллага нь өөрийн хуучин хяналтанд байсан байгууллагадаа хяналтын бус хувь оролцоотой үлдсэн эсэхээс үл хамааран уг хэсэгчилсэн данснаас хасалтын үр дүнд гадаад үйл ажиллагааг өөртөө агуулсан, хяналтанд байсан байгууллага дахь хяналтаа алдах;
  - (б) Гадаад үйл ажиллагааг өөртөө агуулсан хараат компани дахь хувь оролцооны хэсэгчилсэн данснаас хасалт эсвэл хамтын хэлэлцээр дэх хувь оролцооны хэсэгчилсэн данснаас хасалтын дараа түүнд үлдсэн хувь оролцоо нь гадаад үйл ажиллагааг өөртөө агуулсан санхүүгийн хөрөнгө байх.
- 57Б. Гадаад үйл ажиллагааг өөртөө агуулсан, хяналтанд буй байгууллагыг данснаас хасах тохиолдолд тэрхүү хяналтын бус хувь оролцоонд хамаарах тухайн гадаад үйл ажиллагаатай холбоотой валютын ханшийн зөрүүгийн хуримтлагдсан дүнг хуримтлагдсан ашиг, алдагдалд шууд шилжүүлнэ.
- 57В. Гадаад үйл ажиллагааг өөртөө агуулсан, хяналтанд буй байгууллагыг хэсэгчлэн данснаас хасах тохиолдолд, цэвэр хөрөнгө/өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэсэгт хуримтлагдаж байсан уг ханшийн зөрүүний нийт хуримтлагдсан дүнгээс тухайн байгууллага нь хувь тэнцүүлсэн хэсгийг тэрхүү гадаад үйл ажиллагаан дахь хяналтын бус хувь оролцоонд хамааруулан дахин хуваарилна. Гадаад үйл ажиллагааны аливаа бусад хэсэгчилсэн данснаас хасалтын хувьд уг байгууллага нь цэвэр хөрөнгө/өмчид хуримтлагдаж байсан ханшийн зөрүүний нийт хуримтлагдсан дүнгээс зөвхөн хувь тэнцүүлсэн хэсгийг ашиг, алдагдалд шилжүүлнэ.

- 57Г. Данснаас хасалт байдлаар тайлагнадаг 57А параграф дахь бууралтаас бусад тохиолдолд гадаад үйл ажиллагаан дахь тухайн байгууллагын хувь оролцооны хэсэгчилсэн данснаас хасалт нь гадаад үйл ажиллагаан дахь уг байгууллагын өмчлөлийн хувь оролцооны аливаа нэг бууралт болно.
58. Байгууллага нь борлуулах, татан буулгах, хувь нийлүүлсэн капиталыг буцаан төлүүлэх эсвэл тухайн байгууллагын бүх буюу зарим үйл ажиллагааг зогсоох замаар гадаад үйл ажиллагаан дахь өөрийн хувь оролцоог бүрэн буюу хэсэгчлэн данснаас хасаж болно. Ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтын төлбөр нь хөрөнгө оруулалтын буцаалтыг орлох зөвхөн тийм тохиолдолд данснаас хасалтын нэг хэсэг болно. Жишээлбэл; ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг тухайн худалдан авалтын өмнөх ашгаас төлөх. Гадаад үйл ажиллагааны өөрийн алдагдлын эсвэл тухайн хувь оролцоог эзэмшиж буй байгууллагын хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын улмаас тухайн гадаад үйл ажиллагааны дансны үнэд гарсан бууралт нь хэсэгчилсэн данснаас хасалт болохгүй, түүнийг орлохгүй. Иймээс гадаад валютын ханшийн зөрүүгийн хойшлогдсон олз буюу гарзын аливаа хэсгийг тухайн дансны үнийн бууралтыг хийсэн үед ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөхгүй.

### **Ханшийн зөрүүгийн татварын үр нөлөө**

59. Орлогын албан татвар төлөх, тайлагнагч байгууллагуудын хувьд, (а) гадаад валютаарх ажил гүйлгээний олз, гарзтай холбоотой татварын үр нөлөө, (б) тухайн байгууллагын санхүүгийн үр дүн, санхүүгийн байдлыг (үүн дотроо гадаад үйл ажиллагааг) өөр валютанд хөрвүүлснээс үүссэн ханшийн зөрүүгийн бүртгэлийн заавар удирдамжийг орлогын албан татварын талаархи олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартуудаас харж болно.

### **Тодруулга**

60. **62, 64-66-р параграфт заасан ‘бүртгэлийн валют’ нь эдийн засгийн нэгдмэл байгууллагын хувьд түүний хяналт тавигч байгууллагын бүртгэлийн валютанд хамаарна.**
61. **Байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:**
- (а) **УСНББОУС 29-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хэрэглүүрээс үүссэн ханшийн зөрүүгээс бусад, ашиг алдагдалд хүлээн зөвшөөрсөн ханшийн зөрүүгийн дүн.**
  - (б) **Цэвэр хөрөнгө/өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэсэгт ангилсан ханшийн цэвэр зөрүү болон уг ханшийн зөрүүгийн тухайн тайлант үеийн эхэн ба эцэс дэх дүнгүүдийн хоорондох тохируулгын тайлан.**



62. Толилуулгын валют нь бүртгэлийн валютаас өөр байх тохиолдолд энэ тухай, түүнчлэн уг бүртгэлийн валют болон толилуулгад өөр валют ашигласан шалтгааны тодруулгын хамт илэрхийлнэ.
63. Тайлагнагч байгууллага эсвэл түүний томоохон гадаад үйл ажиллагааны бүртгэлийн валютыг өөрчилсөн тохиолдолд энэ тухай болон бүртгэлийн валютыг өөрчлөх болсон шалтгааны талаар тодруулга хийнэ.
64. Байгууллага нь өөрийн бүртгэлийн валютаас өөр валютаар санхүүгийн тайлангаа толилуулдаг тохиолдолд уг байгууллага нь холбогдох Стандарт нэг бүрийн бүх шаардлагуудыг, үүн дотроо 44 ба 48-р параграфт заасан хөрвүүлэлтийн аргыг даган мөрддөг зөвхөн тийм тохиолдолд тухайн санхүүгийн тайланг УСНББОУС-тай нийцсэн гэж тодорхойлно.
65. Зарим тохиолдолд байгууллага нь 64-р параграфын шаардлагуудыг ханган биелүүлэхгүйгээр өөрийн бүртгэлийн валютаас өөр валютаар санхүүгийн тайлан буюу бусад санхүүгийн мэдээллээ толилуулдаг. Жишээлбэл; байгууллага нь өөрийн санхүүгийн тайлангаас зөвхөн сонгон авсан зүйлсээ өөр валютанд хөрвүүлж болох юм. Эсвэл бүртгэлийн валют нь хэт инфляцитай эдийн засгийн үеийн валют биш байх байгууллага нь санхүүгийн тайлангийн бүх зүйлсээ хамгийн сүүлийн үеийн хаалтын ханшаар хөрвүүлснээр тухайн санхүүгийн тайланг өөр валютаар илэрхийлж болно. Ийм хөрвүүлэлт нь УСНББОУС-тай нийцэхгүй бөгөөд 66-р параграфт заасан тодруулгыг хийх шаардлагатай байдаг.
66. Байгууллага нь өөрийн бүртгэлийн валют эсвэл толилуулгын валютын аль алинаас өөр валютаар санхүүгийн тайлан буюу бусад санхүүгийн мэдээллээ бэлтгэн харуулдаг бөгөөд 64-р параграфын шаардлагуудыг ханган биелүүлээгүй тохиолдолд уг байгууллага нь:
- (а) УСНББОУС-тай нийцсэн мэдээллээс ялгахын тулд тухайн мэдээллийг нэмэлт мэдээлэл гэдгийг илт ойлгомжтой тодорхойлж илэрхийлнэ;
  - (б) Тухайн нэмэлт мэдээллийг бэлтгэн харуулсан уг валютаа тодруулна;
  - (в) Тухайн байгууллагын бүртгэлийн валют болон уг нэмэлт мэдээллийг тодорхойлоход ашигласан хөрвүүлэлтийн аргыг тодруулна.

## **Шилжилтийн нөхцөл**

### **Аккруэл нягтлан бодох бүртгэлийг анх удаа мөрдөх**

67. [Хассан]

68. [Хассан]

**Бүх байгууллагуудад зориулсан шилжилтийн нөхцлүүд**

69. [Хассан]

70. [Хассан]

**Хүчин төгөлдөр болох хугацаа**

71. Байгууллага нь энэхүү Стандартыг 2010 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2010 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.

71А. 2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-ийн үр дүнд 67, 68, 69, 70, 72-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед УСНББОУС 33-ыг мөрдсөн бол эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.

71Б. 2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан* ба УСНББОУС 37, *Хамтын Хэлэлцээр*-ийн үр дүнд 3(б), 10, 13, 21, 22, 38, 47, 50, 51, 53, 55, 57-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулж, 57А, 57Б, 57В, 57Г параграфуудыг шинээр нэмсэн. Байгууллага нь УСНББОУС 35 ба УСНББОУС 37-г мөрдсөн үеэс эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг дагаж мөрдөнө.

71В. 2016 оны 4 дүгээр сард гаргасан УСНББОУС-ын *Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 6, 7-р параграфуудыг хасаж, 13-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.

72. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

**УСНББОУС 4 (2006)-өөс татгалзах**

73. Энэ Стандарт нь 2006 онд гаргасан УСНББОУС 4, *Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө*-г орлоно.

## Дүгнэлтийн Үндэслэл

Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 4-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

### Оршил

- ДҮ1. УСНББОУС3-ийн СТОУС-тай нийцүүлэх хөтөлбөр нь УСНББОУС3-ийн ажлын хөтөлбөрийн чухал элемент юм. УСНББОУС3-ийн бодлого нь улсын секторын байгууллагуудад тохиромжтой тохиолдолд НББОУС3-өөс гаргасан СТОУС-тай аккруэл суурьт УСНББОУС-ыг нийцүүлэх явдал юм.
- ДҮ2. Улсын секторын хувьд гажих тусгай учир шалтгаан байхаас бусад тохиолдолд СТОУС-тай нийцүүлсэн, аккруэл суурьт УСНББОУС нь СТОУС-ын шаардлага, бүтэц, текстийг тэр хэвээр хадгална. СТОУС-ын шаардлага буюу нэр томъёо нь улсын секторт тохиромжгүй эсвэл улсын секторын хувьд зарим тодорхой шаардлагуудыг үлгэрчлэн харуулахын тулд нэмэлт тайлбар буюу жишээ оруулах шаардлагатай тохиолдолд адилтгах СТОУС-аас гаждаг. УСНББОУС-ууд ба тэдгээртэй адилтгах СТОУС-уудын хоорондох ялгаатай талуудыг УСНББОУС нэг бүрд тусган оруулсан *СТОУС-тай Харьцуулалт*-д тодорхойлсон. НББОУС 21-тэй хийсэн харьцуулалт нь 2003 онд хянан засварласан ба 2005 онд нэмэлт өөрчлөлт оруулсан, НББОУС 21-ийн хувилбарыг зөвхөн лавлагаа болгосон.<sup>1</sup>
- ДҮ3. 2000 оны 5 дугаар сард УСНББОУС3-ийн өмнөх байгууллага болох Улсын Секторын Хороо (УСХ)<sup>2</sup> нь НББОУС 21, *Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө* (1993)-д үндэслэсэн, УСНББОУС 4, *Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө*-ний анхны хувилбарыг гаргасан. Ерөнхий Сайжруулалтын Төслийн нэг хэсэг болох НББОУС 21 (2003 онд хянан засварласан)-д үндэслэн УСНББОУС3 нь УСНББОУС 4-ийг 2006 оны 12 дугаар сард хянан засварласан. 2005 оны 12 дугаар сард НББОУС3 нь НББОУС 21-ийн нэмэлт өөрчлөлтийг гаргасан (*Гадаад Үйл Ажиллагаан дахь Цэвэр Хөрөнгө Оруулалт* гэж хэвлэн нийтэлсэн).
- ДҮ4. 2007 оны эхээр УСНББОУС3 нь улсын секторын хувьд тохиромжтой тохиолдолд хамгийн сүүлийн үеийн холбогдох СТОУС-тай нийцүүлэхийн тулд одоо байгаа УСНББОУС-уудыг баяжуулах үүднээс байнгын сайжруулалтын төслийг санаачлан эхлүүлсэн. Энэхүү төслийн нэг хэсэг

---

<sup>1</sup> НББОУС3-ийн өмнөх байгууллага болох Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Хорооноос Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС)-ыг гаргасан. НББОУС3-өөс гаргасан стандартуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) гэж нэрлэдэг. СТОУС-ыг НББОУС3 нь СТОУС, НББОУС, Стандартын Тайлбаруудаас бүрдэнэ гэж тодорхойлсон. Зарим тохиолдолд НББОУС3 нь НББОУС-ыг сольж орлуулахгүй, харин нэмэлт өөрчлөлт оруулдаг бөгөөд ингэснээр хуучин НББОУС-ын дугаарлалт хэвээр үлддэг.

<sup>2</sup> ДНБОУХ-ны Зөвлөл нь УСХ-г стандарт тогтоох бие даасан зөвлөл болгохын тулд түүний бүрэн эрхийг 2004 оны 11 дүгээр сард өөрчилснөөр УСХ нь УСНББОУС3 болсон.

болгон УСНББОУСЗ нь 2005 оны 12 дугаар сард НББОУСЗ-өөс гаргасан НББОУС 21-ийн нэмэлт өөрчлөлтийг нягталж шалгаад уг НББОУС-д нэмэлт өөрчлөлт оруулах болсон НББОУСЗ-ийн учир шалтгаан болон хийсэн нэмэлт өөрчлөлттэй ерөнхийдөө санал нэгдсэн. (Энэхүү нэмэлт өөрчлөлтийн үр дүн болох НББОУСЗ-ийн Дүгнэлтийн Үндэслэлийг энд дахин нийтлээгүй болно. НББОУСЗ-ийн *Цогц Захиалгын Үйлчилгээ*-гээр захиалагч нар нь [www.iasb.org](http://www.iasb.org) хаягаар орж, НББОУСЗ-ийн вэб сайтаас Дүгнэлтийн Үндэслэлийг үзэж болно).

ДҮ5. 2005 оны 12 дугаар сараас хойш гаргасан СТОУС-ууд болон хянан засварласан НББОУС-уудын үр дүнд НББОУС 21-д цаашид нэмэлт өөрчлөлт оруулсан. 2005 оны 12 дугаар сараас хойш гаргасан СТОУС-ууд буюу хянан засварласан НББОУС-уудын үр дүн болох нэмэлт өөрчлөлтүүдийг УСНББОУС 4-д тусган оруулаагүй байна. Яагаад гэвэл, УСНББОУСЗ нь тэдгээр СТОУС-уудын шаардлагуудыг нягтлан шалгаж, улсын секторын байгууллагуудад мөрдөгдөх боломжит байдлын талаар өөрийн үзэл бодлыг хараахан илэрхийлээгүй байгаа юм.

**2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУСЗ-ийн *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ын үр дүнд УСНББОУС 4-д хийсэн хянан засварлалт**

ДҮ6. УСНББОУСЗ нь 2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (а) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р* параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

## НББОУС 21-ТЭЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 4, *Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө*-г НББОУС 21, *Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө* (2003 онд хянан засварласан хувилбарт 2005 онд нэмэлт өөрчлөлт оруулсан)-нөөс үндсэндээ бэлтгэсэн. УСНББОУС 4 ба НББОУС 21-ийн хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- УСНББОУС 4 нь зарим тохиолдолд НББОУС 21-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь УСНББОУС 4 дэх “орлого” /revenue/, “эдийн засгийн нэгдмэл байгууллага”, “санхүүгийн үр дүнгийн тайлан”, “цэвэр хөрөнгө/өмч” гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. НББОУС 21 дэх адилтгах нэр томъёо нь “орлого” /income/, “групп”, “дэлгэрэнгүй орлогын тайлан”, “өмч” юм.

## УСНББОУС 5–ЗЭЭЛИЙН ӨРТӨГ

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) 23, *Зээлийн Өртөг* (1993 онд хянан засварласан)-өөс үндсэндээ бэлтгэсэн болно. НББОУС 23-аас авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон ЕС4М 6ХН, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)

Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.

## УСНББОУС 5-ЗЭЭЛИЙН ӨРТӨГ

### УСНББОУС-ЫН ТҮҮХ

Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

УСНББОУС 5, Зээлийн Өртөг-ийг 2000 оны 5 дугаар сард гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 5-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 32, Үйлчилгээний Концессын Хэлцэл: Эрх бүхий этгээд (2011 оны 10 дугаар сард гаргасан)

### УСНББОУС 5-ЫН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН ПАРАГРАФУУДЫН ХҮСНЭГТ

Өөрчлөгдсөн параграф	Хэрхэн өөрчилсөн	Юугаар өөрчилсөн
2	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
3	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
6	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 32, 2011 оны 10-р сар
11	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
19	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
41	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
42A	Шинэ	УСНББОУС 32, 2011 оны 10-р сар
42Б	Шинэ	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
42B	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
43	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар



## УСНББОУС 5–ЗЭЭЛИЙН ӨРТӨГ

## АГУУЛГА

	Параграф
Зорилго	
Цар хүрээ	1-4
Тодорхойлолт	5-13
Зээлийн өртөг	6
Эдийн засгийн нэгдмэл байгууллага	7-9
Ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи	10
Улсын Үйлдвэрийн Газар	11
Цэвэр хөрөнгө/Өмч	12
Шалгуур хангах хөрөнгө	13
Зээлийн өртөг-Бенчмарк хандлага	14-16
Хүлээн зөвшөөрөлт	14-15
Тодруулга	16
Зээлийн өртөг-Зөвшөөрөгдсөн сонголтот хандлага	17-39
Хүлээн зөвшөөрөлт	17-20
Капиталжуулах боломжтой зээлийн өртөг	21-29
Шалгуур хангах хөрөнгийн нөхөгдөх дүнгээс давсан дансны үнэ	30
Капиталжуулалтын эхлэл	31-33
Капиталжуулалтыг хойшлуулах	34-35
Капиталжуулалтыг зогсоох	36-39
Тодруулга	40
Шилжилтийн нөхцөл	41
Хүчин төгөлдөр болох хугацаа	42-43
Дүгнэлтийн үндэслэл	
НББОУС 23-тай харьцуулалт	

## ЗЭЭЛИЙН ӨРТӨГ

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 5, *Зээлийн Өртөг*-ийг зорилго хэсэг болон 1-43-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 5-ыг түүний зорилгын агуулга, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

Энэ Стандарт нь зээлийн өртгийн нягтлан бодох бүртгэлийн хандлагыг тодорхойлно. Энэ Стандарт нь зээлийн өртгийг нэн даруй зардал болгохыг ерөнхийдөө шаарддаг. Гэвч шалгуур хангах хөрөнгийн худалдан авалт, барьж байгуулалт буюу үйлдвэрлэлтэнд шууд хамаарах зээлийн өртгийг зөвшөөрөгдсөн сонголтот хандлага байдлаар капиталжуулахыг энэхүү Стандартаар зөвшөөрдөг.

## Цар хүрээ

1. **Зээлийн өртгийг тайлагнахдаа энэхүү Стандартыг дагаж мөрдөнө.**
2. [Хассан]
3. [Хассан]
4. Энэ Стандарт нь цэвэр хөрөнгө/өмчийн бодит буюу тооцоолсон өртөгт хамаарахгүй. Улс орнууд нь бие даасан байгууллагуудад капиталын хураамж ногдуулдаг тохиолдолд уг хураамж нь зээлийн өртгийн тодорхойлолтыг хангах эсэх, түүнийг цэвэр хөрөнгө/өмчийн бодит эсвэл тооцоолсон өртөг гэж үзэх эсэхийг тодорхойлохын тулд шүүн тунгаалт хийх шаардлагатай байдаг.

## Тодорхойлолт

5. **Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:**

**Зээлийн өртөг** гэдэг нь мөнгө санг зээлдэн авахтай холбоотойгоор байгууллагын гаргах хүүний болон бусад зардал юм.

**Шалгуур хангах хөрөнгө** гэдэг нь түүнийг зориулалтын дагуу ашиглах эсвэл борлуулахад бэлэн болгоход нилээд их цаг хугацааг зайлшгүй шаарддаг хөрөнгө юм.

**Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д дахин нийтэлсэн болно.**

## Зээлийн өртөг

6. Зээлийн өртөгт дараах зүйлс багтаж болно:
  - (а) Банкны овердрафт, богино болон урт хугацаат зээлийн хүү;
  - (б) Зээлтэй холбоотой хөнгөлөлт, урамшууллын хорогдуулга;
  - (в) Зээлийн гэрээтэй холбоотойгоор гарсан нэмэлт өртөг зардлын хорогдуулга;

## ЗЭЭЛИЙН ӨРТӨГ

- (г) Санхүүгийн түрээс болон үйлчилгээний концессын хэлцэлтэй холбоотой санхүүгийн хураамж; ба
- (д) Гадаад валютын зээлээс үүссэн бөгөөд хүүний зардлын тохируулга гэж үзэх тохиолдолд ханшийн зөрүү.

### **Эдийн засгийн нэгдмэл байгууллага**

- 7. Хяналт тавигч байгууллага ба түүний хяналтанд буй аливаа байгууллагуудаас бүрдэх байгууллагуудын группыг санхүүгийн тайлагналын зорилгоор тодорхойлохын тулд энэ Стандартад эдийн засгийн нэгдмэл байгууллага гэсэн нэр томъёог ашигласан.
- 8. Эдийн засгийн нэгдмэл байгууллагыг илэрхийлэхийн тулд зарим үед захиргааны байгууллага, санхүүгийн байгууллага, нэгтгэсэн байгууллага, групп гэх мэт нэр томъёог ашигладаг.
- 9. Эдийн засгийн нэгдмэл байгууллага нь нийгмийн бодлогын болон арилжааны аль аль зорилго бүхий байгууллагуудыг агуулсан байж болно. Жишээлбэл; төрийн орон сууцны удирдах газар нь нэрлэсэн хөлстэйгээр орон байраар хангадаг байгууллагууд, түүнчлэн арилжааны зорилгоор орон сууцаар хангадаг байгууллагуудын аль алиныг агуулсан, эдийн засгийн нэгдмэл байгууллага байж болно.

### **Ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи**

- 10. Хөрөнгө нь өөрийнхөө зорилтонд хүрэх арга хэрэгслээр байгууллагыг хангадаг. Байгууллагын зорилтын дагуу бараа, үйлчилгээг нийлүүлэхэд ашигладаг боловч цэвэр мөнгөн орлогын гүйлгээг шууд үүсгэн бий болгодоггүй хөрөнгүүдийг “үйлчилгээний чадавхи агуулсан” гэж ихэвчлэн нэрлэдэг. Цэвэр мөнгөн орлогын гүйлгээг бий болгоход ашигладаг хөрөнгүүдийг “ирээдүйн эдийн засгийн үр өгөөж агуулсан” гэж ихэвчлэн нэрлэдэг. Хөрөнгийг ашиглаж болох бүх зорилгыг нэгтгэн илэрхийлэхийн тулд энэ Стандарт нь хөрөнгүүдийн чухал шинж чанаруудыг тодорхойлох үүднээс “ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи” гэсэн нэр томъёог ашигласан.

### **Улсын Үйлдвэрийн Газар**

- 11. [Хассан]

### **Цэвэр хөрөнгө/Өмч**

- 12. Цэвэр хөрөнгө/өмч нь санхүүгийн байдлын тайлан дахь үлдэх хэмжүүрийг (хөрөнгөөс өр төлбөрийг хасах) илэрхийлэхийн тулд энэ Стандартад ашигласан нэр томъёо юм. Цэвэр хөрөнгө/өмч нь эерэг эсвэл сөрөг утгатай байж болно. Хэрэв утга нь ойлгомжтой бол цэвэр хөрөнгө/өмчийн оронд өөр нэр томъёог ашиглаж болно.

### **Шалгуур хангах хөрөнгө**

13. Шалгуур хангах хөрөнгийн жишээнд оффисын барилга, эмнэлэг, түүнчлэн зам, гүүр, цахилгаан станц гэх мэт дэд бүтцийн хөрөнгө, ашиглах буюу борлуулахад бэлэн тийм нөхцөл байдалд оруулахад мэдэгдэхүйц их цаг хугацаа шаардах бараа материал хамаарна. Бусад хөрөнгө оруулалт, түүнчлэн богино хугацааны дотор байнга тогтмол үйлдвэрлэдэг хөрөнгүүд нь шалгуур хангах хөрөнгө биш юм. Олж эзэмших үед тэдгээрийг зориулалтын дагуу ашиглах буюу борлуулахад бэлэн байгаа хөрөнгүүд нь шалгуур хангах хөрөнгө биш юм.

### **Зээлийн өртөг-Бенчмарк хандлага**

#### **Хүлээн зөвшөөрөлт**

14. **Зээлийн өртгийг тэдгээрийн гарсан тайлант үед зардал гэж хүлээн зөвшөөрнө.**
15. Тухайн зээлийг хэрхэн ашигласнаас үл хамааран бенчмарк хандлагын дагуу зээлийн өртгийг тэдгээрийн гарсан тайлант үед зардал гэж хүлээн зөвшөөрнө.

#### **Тодруулга**

16. **Зээлийн өртгийн хувьд баримталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогыг санхүүгийн тайланд тодруулна.**

### **Зээлийн өртөг-Зөвшөөрөгдсөн сонголтот хандлага**

#### **Хүлээн зөвшөөрөлт**

17. **18-р параграфын дагуу капиталжуулснаас бусад тохиолдолд зээлийн өртгийг тэдгээрийн гарсан тайлант үед зардал гэж хүлээн зөвшөөрнө.**
18. **Шалгуур хангах хөрөнгийн худалдан авалт, барьж байгуулалт буюу үйлдвэрлэлд шууд хамааруулж болох зээлийн өртгийг тухайн хөрөнгийн өртгийн нэг хэсэг болгон капиталжуулна. Капиталжуулах боломжтой зээлийн өртгийн дүнг энэхүү Стандартын дагуу тодорхойлно.**
19. Хөрөнгийн худалдан авалт, барьж байгуулалт буюу үйлдвэрлэлд шууд хамааруулж болох зээлийн өртгийг зөвшөөрөгдсөн сонголтот хандлагын дагуу тухайн хөрөнгийн өртөгт тусган оруулна. Ийм зээлийн өртгийг (а) тухайн байгууллагад ирээдүйд эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бий болгох нилээд их магадлалтай, ба (б) өртгийг найдвартайгаар хэмжиж чадах тохиолдолд уг хөрөнгийн өртгийн нэг хэсэг

болгон капиталжуулна.<sup>1</sup> Бусад зээлийн өртгийг тэдгээрийн гарсан тайлант үед зардал гэж хүлээн зөвшөөрнө.

20. **Байгууллага нь зөвшөөрөгдсөн сонголтот хандлагыг хэрэглэдэг тохиолдолд тухайн байгууллагын шалгуур хангах бүх хөрөнгийн худалдан авалт, барьж байгуулалт буюу үйлдвэрлэлд шууд хамааруулж болох бүх зээлийн өртөгт уг хандлагыг тууштай мөрдөнө.**

#### **Капиталжуулах боломжтой зээлийн өртөг**

21. Шалгуур хангах хөрөнгийн худалдан авалт, барьж байгуулалт буюу үйлдвэрлэлд шууд хамааруулж болох зээлийн өртөг нь хэрэв уг шалгуур хангах хөрөнгийн хувьд зарцуулалт хийгдээгүй бол гаргахгүйгээр зайлсхийж болох байсан зээлийн өртөг юм. Байгууллага нь шалгуур хангах тодорхой нэг хөрөнгийг олж авах зорилгоор мөнгө санг тусгайлан зээлдэж авсан тохиолдолд уг шалгуур хангах хөрөнгөнд шууд хамаарах зээлийн өртгийг хялбархан тодорхойлж чадна.
22. Тухайн тодорхой зээл ба шалгуур хангах хөрөнгийн хоорондох шууд харилцан холбоог тогтоох, түүнчлэн уг хөрөнгө байгаагүй бол зайлсхийж болох байсан зээлийг тодорхойлоход хүндрэлтэй байж болох юм. Тухайлбал; байгууллагын санхүүжилтийн үйл ажиллагааг төвлөрсөн байдлаар уялдан зохицуулдаг тохиолдолд ийм хүндрэл үүсдэг. Эдийн засгийн нэгдмэл байгууллага нь мөнгө санг зээлдэн авахын тулд янз бүрийн хүүтэй олон тооны өрийн хэрэглүүрийг ашигладаг бөгөөд тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын бусад байгууллагуудад өөр өөр хүүтэйгээр зээлдүүлдэг тохиолдолд мөн хүндрэл үүсдэг. Төвлөрсөн байдлаар зээлдэн авсан мөнгө санг уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрэн дэх бусад байгууллагуудад зээл, буцалтгүй тусламж, капитал оруулалт байдлаар шилжүүлж болох юм. Ийм шилжүүлэг нь хүүгүй эсвэл зөвхөн бодит хүүний зардлын хэсгийг нөхөхөөр байхыг шаардаж болох юм. Бусад хүндрэл бэрхшээлүүд нь (а) гадаад валютаар илэрхийлэгдсэн буюу гадаад валюттай холбоотой зээл авсанаар, (б) эдийн засгийн нэгдмэл байгууллага нь өндөр инфляцитай эдийн засагт үйл ажиллагаагаа явуулдаг тохиолдолд, (в) валютын ханш хэлбэлзэн өөрчлөгдсөнөөр үүсдэг. Иймээс шалгуур хангах хөрөнгийн худалдан авалтанд шууд хамааруулж болох зээлийн өртгийн дүнг тодорхойлоход хүндрэлтэй бөгөөд шүүн тунгаалт хийх шаардлагатай байдаг.
23. **Шалгуур хангах хөрөнгийг олж авах зорилгоор мөнгө санг тусгайлан зээлдэн авсан тохиолдолд тайлант үеийн туршид уг зээлийн хувьд гарсан зээлийн бодит өртгөөс тэрхүү зээлийг түр хугацаагаар эргэлдүүлэн хөрөнгө оруулалт хийснээр олсон аливаа хөрөнгө**

<sup>1</sup> Найдвартай мэдээлэл нь материаллаг алдаа ба туйлшралаас ангид байх бөгөөд өөрийн илэрхийлэхээр зориулагдсан буюу илэрхийлнэ гэж үл үндэслэлтэйгээр хүлээж болох зүйлсийг үнэн зөв илэрхийлэхдээ хэрэглэгчдээс хамаардаг байж болох юм. Найдвартай байдлын тайлбарын талаархи шилжилтийн арга хандлагыг УСНББОУС 1-ийн ДҮ16-р параграфт авч хэлэлцсэн.

**оруулалтын орлогыг хасаж, тухайн хөрөнгийн хувьд капиталжуулах боломжтой зээлийн өртгийн дүнг тодорхойлно.**

24. Шалгуур хангах хөрөнгийн санхүүжилтийн хэлцэл арга хэмжээний үр дүнд тухайн байгууллага нь уг шалгуур хангах хөрөнгөнд зориулан ашиглах бүх буюу зарим мөнгө сангаа зарцуулахаас өмнө зээл авсан ба холбогдох зээлийн хүүний зардал гаргасан байж болно. Ийм тохиолдолд тэрхүү шалгуур хангах хөрөнгөнд зориулан зарцуулалт хийгдэхээр хүлээгдэж байх явцад тухайн мөнгө сангаар ихэвчлэн түр хугацаанд хөрөнгө оруулалт хийдэг. Тайлант үеийн туршид капиталжуулах боломжтой зээлийн өртгийн дүнг тодорхойлохдоо, ийм мөнгө сангаас олсон аливаа хөрөнгө оруулалтын орлогыг тухайн гарсан зээлийн өртгөөс хасаж тооцно.
25. **Мөнгө санг ерөнхий зориулалтаар зээлдэн авсан боловч шалгуур хангах хөрөнгийг олж авах зорилгоор тэрхүү мөнгө санг ашиглан зарцуулсан тохиолдолд тухайн хөрөнгөнд хийгдсэн зарлагын дүнг капиталжуулалтын хувь хэмжээгээр үржүүлснээр капиталжуулах боломжтой зээлийн өртгийн дүнг тодорхойлно. Капиталжуулалтын хувь хэмжээ нь шалгуур хангах хөрөнгийг олж авах зорилгоор тусгайлан авсан зээлээс бусад, тухайн тайлант үеийн туршид төлөгдөөгүй байгаа уг байгууллагын бүх зээлд хамаарах зээлийн өртгийн жинэлсэн дундаж байна. Тайлант үеийн туршид капиталжуулах зээлийн өртгийн дүн нь тухайн тайлант үед гарсан зээлийн өртгийн нийт дүнгээс хэтрэх ёсгүй.**
26. Тухайн байгууллагын зээлд хамааруулж болох зөвхөн тэдгээр зээлийн өртгийг капиталжуулж болно. Хяналт тавигч байгууллага нь мөнгө санг зээлдэн авсан бөгөөд зээлийн өртгийг хуваарилахгүйгээр эсвэл түүний зөвхөн зарим хэсгийг хуваарилснаар уг мөнгө санг өөрийн хяналтанд буй байгууллагад шилжүүлсэн тохиолдолд тухайн хяналтанд буй байгууллага нь зөвхөн өөрийн гаргасан зээлийн өртгийг капиталжуулж болно. Хяналтанд буй байгууллага нь хүүгүй капиталын хувь нийлүүлэлт эсвэл капиталын буцалтгүй тусламж хүлээн авсан тохиолдолд уг хяналтанд буй байгууллага нь ямар нэг зээлийн өртөг зардал гаргахгүй бөгөөд ийм ямар нэг өртөг зардлыг капиталжуулахгүй.
27. Хяналт тавигч байгууллага нь хяналтанд буй байгууллагадаа мөнгө санг түүний зардлын зарим хэсгийг хариуцан шилжүүлдэг тохиолдолд уг хяналтанд буй байгууллага нь зээлийн өртгөөс зөвхөн өөрийн гаргасан хэсгийг капиталжуулж болно. Уг хяналтанд буй байгууллагын капиталжуулсан зээлийн өртгийг устгахын тулд нэгтгэлийн зохих тохируулгыг хийдэг бол тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын санхүүгийн тайланд тэдгээр зээлийн өртгийн нийт дүнгээр тэрхүү шалгуур хангах хөрөнгөнд капиталжуулж болно.
28. Хяналт тавигч байгууллага нь хяналтанд буй байгууллагадаа мөнгө санг ямар нэг хүүний зардалгүйгээр шилжүүлдэг тохиолдолд уг хяналт тавигч байгууллага ба хяналтанд буй байгууллагын аль аль нь зээлийн өртгийг капиталжуулах шалгуурыг хангахгүй юм. Гэвч эдийн засгийн нэгдмэл

## ЗЭЭЛИЙН ӨРТӨГ

байгууллага нь зээлийн өртгийг капиталжуулах шалгуурыг хангасан бол уг эдийн засгийн нэгдмэл байгууллага нь өөрийн санхүүгийн тайлан дахь тухайн шалгуур хангах хөрөнгөнд зээлийн өртгийг капиталжуулж болно.

29. Зарим тохиолдолд зээлийн өртгийн жинэлсэн дундаж дүнг тооцоходоо, уг хяналт тавигч байгууллага болон түүний хяналтанд буй байгууллагуудын бүх зээлийг оруулах нь тохиромжтой байдаг. Өөр зарим тохиолдолд, хяналтанд буй байгууллага тус бүрийн зээлд хамаарах зээлийн өртгийн жинэлсэн дундажийг ашиглах нь тохиромжтой байж болно.

### **Шалгуур хангах хөрөнгийн нөхөгдөх дүнгээс давсан дансны үнэ**

30. Шалгуур хангах хөрөнгийн дансны үнэ буюу хүлээгдэж буй эцсийн өртөг нь түүний нөхөгдөх дүн эсвэл цэвэр боломжит үнэ цэнээс давсан тохиолдолд УСНББОУС 21, *Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт* ба УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-ын аль тохиромжтой стандартын шаардлагуудын дагуу дансны үнийг бууруулах буюу хасалт хийнэ. Зарим тохиолдолд тэрхүү бууруулсан буюу данснаас хассан дүнг өөр бусад стандартуудын дагуу буцаадаг.

### **Капиталжуулалтын эхлэл**

31. **Шалгуур хангах хөрөнгийн өртгийн нэг хэсэг болох зээлийн өртгийн капиталжуулалт нь дараах тохиолдолд эхэлнэ:**
- (а) **Тухайн хөрөнгийн хувьд зарлага гаргасан;**
  - (б) **Зээлийн өртөг зардал гарсан; ба**
  - (в) **Тухайн хөрөнгийг түүний зориулалтын дагуу ашиглах эсвэл борлуулах үүднээс бэлтгэхэд шаардлагатай үйл ажиллагааг эхэлсэн.**
32. Шалгуур хангах хөрөнгөнд хийгдэх зарлага нь мөнгөн төлбөр хийх, бусад хөрөнгийг шилжүүлэх эсвэл хүүтэй өр төлбөр үүсэхэд хүргэх зөвхөн тийм зарлагуудаас бүрдэнэ. Өмнө нь капиталжуулсан зээлийн өртгийг багтаасан тухайн хөрөнгийн тайлант үеийн дундаж дансны үнэ нь уг хөрөнгөнд хийгдсэн зарлагын ул үндэслэлтэй ойролцоо тооцоолол ихэвчлэн болох бөгөөд тайлант үед тэрхүү дүнд капиталжуулалтын түвшинг хэрэглэнэ.
33. Хөрөнгийг түүний зориулалтын ашиглалт буюу борлуулалтанд бэлтгэхэд шаардлагатай үйл ажиллагаа нь тухайн хөрөнгийг биетээр барьж байгуулахаас илүү өргөн хүрээтэй байдаг. Үүнд: хөрөнгийг биетээр барьж байгуулах ажиллагааг эхлэхээс өмнөх техникийн болон захиргаа удирдлагын ажил хамаарна. Жишээлбэл; зохих зөвшөөрлүүдийг олж авахтай холбоотой үйл ажиллагаа. Гэхдээ тухайн хөрөнгийн төлөв байдлыг өөрчлөх үйлдвэрлэл буюу хөгжүүлэлт хийгдээгүй байх үеийн хөрөнгийн эзэмшилт нь ийм үйл ажиллагаанд хамаарахгүй. Жишээлбэл; газрыг хөгжүүлэх явцад гарсан зээлийн өртгийг тухайн хөгжүүлэлттэй



## ЗЭЭЛИЙН ӨРТӨГ

холбоотой үйл ажиллагааг гүйцэтгэсэн тайлант үеийн туршид капиталжуулна. Харин барилга барих зорилгоор худалдаж авсан газрыг холбогдох ямар нэг хөгжүүлэлтийн үйл ажиллагаа хийхгүйгээр эзэмших явцад гарсан зээлийн өртөг нь капиталжуулалтын шалгуурыг хангахгүй юм.

### Капиталжуулалтыг хойшлуулах

34. **Шалгуур хангах хөрөнгийн идэвхитэй хөгжүүлэлт тасалдсан тохиолдолд энэхүү сунгасан хугацааны туршид зээлийн өртгийн капиталжуулалтыг хойшлуулж, зардал болгоно.**
35. Хөрөнгийг түүний зориулалтын ашиглалт эсвэл борлуулалтанд бэлтгэхэд шаардлагатай үйл ажиллагаа тасалдсан тохиолдолд тэрхүү сунгасан хугацааны туршид зээлийн өртөг зардал гарсаар байж болох юм. Ийм өртөг нь хэсэгчлэн иж бүрдсэн хөрөнгийн эзэмшилтийн зардал бөгөөд капиталжуулах шалгуурыг хангахгүй. Гэвч техникийн болон захиргаа удирдлагын томоохон ажлыг хийж байгаа бол тухайн тайлант үеийн туршид зээлийн өртгийн капиталжуулалтыг ихэвчлэн хойшлуулдаггүй. Түр хойшлуулалт нь хөрөнгийг түүний зориулалтын ашиглалт эсвэл борлуулалтанд бэлтгэх үйл явцад зайлшгүй гардаг тохиолдолд зээлийн өртгийн капиталжуулалтыг мөн хойшлуулахгүй. Жишээлбэл; усны түвшин дээшилсэний улмаас гүүрний барилгын ажил хойшлогдсон бөгөөд усны түвшний ийм дээшлэлт нь тухайн хамаарах газар зүйн бүс нутаг дахь барилгын ажлын явцад нийтлэг тохиолддог бол бараа материалыг барьж дуусгахад шаардлагатай энэхүү сунгасан хугацааны туршид капиталжуулалтыг үргэлжлүүлэн хийнэ.

### Капиталжуулалтыг зогсоох

36. **Шалгуур хангах хөрөнгийг түүний зориулалтын ашиглалт эсвэл борлуулалтанд бэлтгэхэд шаардлагатай бараг бүх үйл ажиллагаа дууссан үед зээлийн өртгийн капиталжуулалтыг зогсооно.**
37. Захиргаа удирдлагын өдөр тутмын ажил үргэлжилсэн хэвээр байж болох боловч тухайн хөрөнгийг биетээр барьж байгуулах ажиллагаа дууссан тохиолдолд хөрөнгө нь түүний зориулалтын ашиглалт эсвэл борлуулалтанд ихэвчлэн бэлэн болдог. Худалдан авагч буюу хэрэглэгчийн тусгай шаардлагын дагуу үл хөдлөх хөрөнгөнд засал чимэглэл хийх гэх мэт жижиг засвар өөрчлөлт дуусаагүй байлаа ч гэсэн энэ нь бараг бүх үйл ажиллагаа дууссан гэдгийг илэрхийлнэ.
38. **Шалгуур хангах хөрөнгийн барилгын ажил хэсэгчлэн дууссан бөгөөд бусад хэсгүүдийн барилгын ажил үргэлжлэн явагдаж байх үед уг дууссан хэсэг тус бүрийг ашиглах боломжтой тохиолдолд тэрхүү дууссан хэсгийг зориулалтын дагуу ашиглалт буюу борлуулалтанд бэлтгэхэд шаардлагатай бараг бүх ажиллагаа дууссан үеэр түүний зээлийн өртгийн капиталжуулалтыг зогсооно.**

39. Хэд хэдэн барилга, байгууламжаас бүрдэх бөгөөд барилга нэг бүрийг тус тусдаа ашиглаж болох оффисын хөгжүүлэлт нь бусад хэсгүүдийн барилгын ажил үргэлжлэн явагдаж байх үед тэдгээр дууссан хэсэг тус бүрийг ашиглах боломжтой тийм шалгуур хангах хөрөнгийн жишээ болно. Аль нэг хэсгийг ашиглахаас өмнө бүгдийг иж бүрэн дуусгах шаардлагатай тийм шалгуур хангах хөрөнгийн жишээ нь (а) ашиглах боломжтой болохын өмнө бүх барилгын ажлыг дуусгах шаардлагатай, эмнэлгийн мэс заслын цогц өрөө, (б) дэс дараалсан өөр өөр хэсгүүдэд гүйцэтгэгдэх хэд хэдэн дамжлага процесс бүхий цэвэрлэх байгууламж, (в) хурдны замын гүүрийн бүрдэл хэсгүүд.

## Тодруулга

40. Санхүүгийн тайланд дараах зүйлсийг тодруулна:
- (а) Зээлийн өртгийн хувьд баримталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого;
  - (б) Тухайн тайлант үеийн туршид капиталжуулсан зээлийн өртгийн дүн; ба
  - (в) Капиталжуулах боломжтой зээлийн өртгийн дүнг тодорхойлоход ашигласан капиталжуулалтын хувь хэмжээ (ерөнхий зориулалтаар зээлсэн мөнгө сангийн хувьд капиталжуулалтын хувь хэмжээг ашиглах шаардлагатай тохиолдолд).

## Шилжилтийн нөхцөл

41. [Хассан]

## Хүчин төгөлдөр болох хугацаа

42. Байгууллага нь энэхүү Стандартыг 2001 оны 7 дугаар сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2001 оны 7 дугаар сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 42A. 2011 оны 10 дугаар сард гаргасан УСНББОУС 32, *Үйлчилгээний Концессын Хэлцэл: Эрх Бүхий Этгээд*-ийн үр дүнд 6-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2014 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2014 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийж, мөн тэр үеэс УСНББОУС 32, түүнчлэн УСНББОУС 13-ын 25-27 болон 85В параграфуудын нэмэлт өөрчлөлт, УСНББОУС 17-гийн 5, 7, 107В

параграфуудын нэмэлт өөрчлөлт, УСНББОУС 29-ийн 2, 125А параграфуудын нэмэлт өөрчлөлт, УСНББОУС 31-ийн 6, 132А параграфуудын нэмэлт өөрчлөлтүүдийг даган мөрдөнө.

- 42Б. 2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-ийн үр дүнд 41, 43-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед УСНББОУС 33-ыг мөрдсөн бол эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.
- 42В. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 2, 3, 11-р параграфуудыг хассан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
43. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

## Дүгнэлтийн Үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 5-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

**2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУС3-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 5-д хийсэн хянан засварлалт**

ДҮ1. УСНББОУС3 нь 2016 оны 4 дүгээр сард УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (а) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р* параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

## НББОУС 23-ТАЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 5, *Зээлийн Өртөг*-ийг НББОУС 23, *Зээлийн Өртөг* (1993)-өөс үндсэндээ бэлтгэсэн. УСНББОУС 5 ба НББОУС 23-ын хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- УСНББОУС 5 нь зарим тохиолдолд НББОУС 23-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь УСНББОУС 5 дахь “орлого” /*revenue*/, “санхүүгийн үр дүнгийн тайлан”, “цэвэр хөрөнгө/өмч” гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. НББОУС 23 дахь адилтгах нэр томъёо нь “орлого” /*income*/, “орлогын тайлан”, “өмч” юм.
- УСНББОУС 5 нь НББОУС 23 (5-р параграф)-т зааснаас өөр, техникийн нэр томъёоны цогц тодорхойлолтыг агуулсан байдаг.

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) 6, *Нэгтгэсэн ба Тусдаа Санхүүгийн Тайлан*-г УСНББОУС 34, *Тусдаа Санхүүгийн Тайлан* болон УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*-гаар орлуулсан. Эдгээр Стандартуудыг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Үүний үр дүнд УСНББОУС 6-г цаашид мөрдөхгүй бөгөөд хүчингүй болгосон.

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) 7, *Хараат Байгууллага дахь Хөрөнгө Оруулалт*-ыг УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*-аар орлуулсан. Энэхүү Стандартыг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Үүний үр дүнд УСНББОУС 7-г цаашид мөрдөхгүй бөгөөд хүчингүй болгосон.

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) 8, *Хамтарсан Үйлдвэр дэх Хувь Оролцоо*-г УСНББОУС 37, *Хамтын Хэлэлцээр*-ээр орлуулсан. Энэхүү Стандартыг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Үүний үр дүнд УСНББОУС 8-ыг цаашид мөрдөхгүй бөгөөд хүчингүй болгосон.



## УСНББОУС 9–АРИЛЖААНЫ АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) 18, *Орлого* (1993 онд хянан засварласан)-аас үндсэндээ бэлтгэсэн болно. НББОУС 18-аас авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон EC4M 6XH, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)

Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.

## УСНББОУС 9-АРИЛЖААНЫ АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО

### УСНББОУС-ын түүх

Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

УСНББОУС 9, Арилжааны Ажил Гүйлгээний Орлого-ыг 2001 оны 7 дугаар сард гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 9-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 37, Хамтын Хэлэлцээр (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 27, Хөдөө Аж Ахуй (2009 оны 12 дугаар сард гаргасан)
- УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба Хэмжилт (2010 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС-ын Сайжруулалтууд (2010 оны 11 дүгээр сард гаргасан)

### УСНББОУС 9-ийн нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт

Өөрчлөгдсөн параграф	Хэрхэн өөрчилсөн	Юугаар өөрчилсөн
1	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
2	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
3	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
9	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
10	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 27, 2009 оны 12-р сар УСНББОУС 29, 2010 оны 01-р сар УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
12	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
19	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар

АРИЛЖААНЫ АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО

33	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
34	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
36	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
39	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
41А	Шинэ	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
41Б	Шинэ	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар
41В	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
42	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
ХЗУ1	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
ХЗУ12	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 29, 2010 оны 01-р сар
ХЗУ29-ийн дээд талын гарчиг	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
ХЗУ32	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
ХЗУ33	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
ХЗУ34	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар

2001 оны 7 дугаар сар

## УСНББОУС 9–АРИЛЖААНЫ АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО

### АГУУЛГА

---

	Параграф
Зорилго	
Цар хүрээ	1-10
Тодорхойлолт	11-13
Орлого /revenue/	12-13
Орлогын хэмжилт	14-17
Ажил гүйлгээг тодорхойлох	18
Үйлчилгээ үзүүлэх	19-27
Бараа борлуулалт	28-32
Хүү, эрхийн шимтгэл, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт	33-38
Тодруулга	39-40
Хүчин төгөлдөр болох хугацаа	41-42
Хэрэгжүүлэх заавар удирдамж	
НББОУС 18-тай харьцуулалт	

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 9, *Арилжааны Ажил Гүйлгээний Орлого*-ыг зорилгын хэсэг болон 1-42-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 9-ийг түүний зорилгын агуулга, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

НББОУСЗ-ийн *Санхүүгийн Тайланг Бэлтгэх, Толилуулах Үзэл Баримтлал* нь орлогыг /income/ “өмч эзэмшигчдээс оруулсан хувь оролцоотой холбоотойгоос бусад байдлаар өмчийг нэмэгдүүлэх үр дүн бүхий хөрөнгийн орлогын гүйлгээ буюу сайжралт, эсвэл өр төлбөрийн бууралт хэлбэрээр тухайн тайлант үед үүссэн эдийн засгийн үр өгөөжийн өсөлт” гэж тодорхойлсон. НББОУСЗ-ийн орлогын тодорхойлолт нь орлого ба олзын аль алиныг агуулдаг. Энэ Стандартад “орлого” /income/ нэр томъёоны оронд “орлого” /revenue/ гэсэн нэр томъёог ашигласан бөгөөд энэ нь орлого ба олзын аль алиныг агуулна. Орлого гэж хүлээн зөвшөөрөх зарим тодорхой зүйлсийг бусад Стандартуудад авч үзсэн бөгөөд энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй. Жишээлбэл; үндсэн хөрөнгийн борлуулалтаас үүссэн олзыг үндсэн хөрөнгийн Стандартад тусгайлан авч үзсэн бөгөөд энэ Стандартад оруулаагүй.

Энэ Стандартын зорилго нь арилжааны ажил гүйлгээ ба үйл явдлуудаас үүссэн орлогын нягтлан бодох бүртгэлийн хандлагыг тодорхойлоход оршино.

Орлогын нягтлан бодох бүртгэлийн үндсэн асуудал нь орлогыг хэзээ хүлээн зөвшөөрөх эсэхийг тодорхойлох явдал юм. (а) ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь тухайн байгууллагад орох нилээд их магадлалтай, ба (б) эдгээр үр өгөөжийг найдвартай хэмжиж чадах тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрдөг.<sup>1</sup> Энэ Стандарт нь эдгээр шалгуур хангагдах, иймээс орлогыг хүлээн зөвшөөрөх нөхцөл байдлуудыг тодорхойлдог. Стандарт нь мөн эдгээр шалгуурын хэрэглээний талаархи практик заавар удирдамжаар хангадаг.

## Цар хүрээ

1. **Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь дараах арилжааны ажил гүйлгээ ба үйл явдлаас үүссэн орлогыг тайлагнахдаа энэхүү Стандартыг мөрдөнө:**
  - (а) **Үйлчилгээ үзүүлэх;**
  - (б) **Бараа борлуулалт; ба**
  - (в) **Хүү, эрхийн шимтгэл, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг бий болгох уг байгууллагын хөрөнгийг бусдад ашиглуулалт.**
2. [Хассан]
3. [Хассан]

<sup>1</sup> Найдвартай мэдээлэл нь материаллаг алдаа ба туйлшралаас ангид байх бөгөөд өөрийн илэрхийлэхээр зориулагдсан буюу илэрхийлнэ гэж ул үндэслэлтэйгээр хүлээж болох зүйлсийг үнэн зөв илэрхийлэхдээ хэрэглэгчдээс хамаардаг байж болох юм. Найдвартай байдлын тайлбарын талаархи шилжилтийн арга хандлагыг УСНББОУС 1-ийн ДҮ16-р параграфт авч хэлэлцсэн.

4. Арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн орлогод энэ Стандарт хамаарахгүй.
5. Улсын секторын байгууллагууд нь арилжааны болон арилжааны бус ажил гүйлгээнээс орлого олж болно. Арилжааны ажил гүйлгээ гэдэг нь тухайн байгууллага хөрөнгө буюу үйлчилгээг хүлээн авах, эсвэл өр төлбөрийг барагдуулах ба үүний хариуд ойролцоогоор тэнцүү үнэ цэнэ бүхий зүйлсийг (үндсэндээ бараа, үйлчилгээ буюу хөрөнгө ашиглуулах хэлбэрээр) нөгөө талд шууд өгдөг. Арилжааны ажил гүйлгээний жишээнд дараах зүйлс хамаарна:
  - (а) Бараа, үйлчилгээний худалдан авалт буюу борлуулалт;
  - (б) Үндсэн хөрөнгийг зах зээлийн үнийн түвшнээр түрээслүүлэлт.
6. Арилжааны ба арилжааны бус орлогыг өөр хооронд нь ялган тогтоохдоо, тухайн ажил гүйлгээний хэлбэрийг биш, харин мөн чанарыг харгалзан үзнэ. Арилжааны бус ажил гүйлгээний жишээнд бүрэн эрхээ ашигласнаар үүсэх орлого (жишээлбэл; шууд ба шууд бус татвар, хураамж, торгууль), буцалтгүй тусламж, хандив хамаарна.
7. Үйлчилгээ үзүүлэлт нь тохиролцсон үүрэг даалгаврыг тогтоосон хугацаанд хийх уг байгууллагын гүйцэтгэлийг ихэвчлэн агуулсан байдаг. Үйлчилгээг нэг тайлант үеийн дотор эсвэл нэгээс олон тайлант үеийн туршид үзүүлж болно. Улсын секторын байгууллагуудын үзүүлдэг бөгөөд хариуд нь ихэвчлэн орлого олдог үйлчилгээний жишээнд орон сууцаар хангах, усан хангамж, төлбөртэй зам, төлбөрийн шилжүүлгийн менежментийн үйлчилгээ хамаарна. Үйлчилгээ үзүүлэх зарим гэрээ, тухайлбал төслийн менежерийн болон архитекторын үйлчилгээний гэрээ нь барилгын гэрээтэй шууд холбоотой байдаг. Ийм гэрээнээс үүсэх орлогыг энэ Стандартад авч үзээгүй боловч УСНББОУС 11, *Барилгын гэрээ*-нд тусгайлан заасан барилгын гэрээний шаардлагуудын дагуу үүнийг тодорхойлно.
8. Бараа нь (а) борлуулах зорилгоор тухайн байгууллагын үйлдвэрлэн бий болгосон бүтээгдэхүүн, жишээлбэл; ном хэвлэл, (б) буцаан борлуулах зорилгоор худалдан авсан бараа, жишээлбэл; борлуулах зорилгоор эзэмшиж буй бараа бүтээгдэхүүн, газар ба бусад үл хөдлөх хөрөнгөөс бүрдэнэ.
9. Байгууллага хөрөнгөө бусдад ашиглуулснаар дараах хэлбэрийн орлого бий болно:
  - (а) Хүү – мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийн ашиглуулалт буюу тухайн байгууллагад төлөх дүнгийн хувьд тооцсон төлбөр;
  - (б) Эрхийн шимтгэл – тухайн байгууллагын эргэлтийн бус хөрөнгийн ашиглуулалтын хувьд тооцсон төлбөр, жишээлбэл; патент, худалдааны тэмдэг, зохиогчийн эрх, компьютерийн программ хангамж; ба

- (в) Ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт – тухайн тодорхой ангийн капиталын эзэмшилттэй хувь тэнцүүлэн өмчийн хөрөнгө оруулалтын эзэмшигчдэд олгох ашгийн хуваарилалт.
10. Дараах зүйлсээс үүссэн орлогыг энэ Стандартад авч үзэхгүй:
- (а) Түрээсийн гэрээ (УСНББОУС 13, *Түрээс*-ийг үзнэ үү);
- (б) Өмчийн аргын дагуу тайлагнадаг хөрөнгө оруулалтаас үүссэн ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт (УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*-ыг үзнэ үү);
- (в) Үндсэн хөрөнгийн борлуулалтаас үүссэн олз (УСНББОУС 17, *Үндсэн хөрөнгө*-д авч үздэг);
- (г) Даатгалын гэрээг авч үздэг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартын цар хүрээнд хамаарах даатгалын гэрээ;
- (д) Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт эсвэл тэдгээрийн данснаас хасалт (санхүүгийн хэрэглүүрийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийн талаархи заавар удирдамжийг УСНББОУС 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба Хэмжилт*-ээс харж болно);
- (е) Бусад эргэлтийн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлт;
- (ж) Хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой биологийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлт ба түүний бодит үнэ цэнийн өөрчлөлт (УСНББОУС 27, *Хөдөө Аж Ахуй*-г үзнэ үү);
- (и) Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний анхны хүлээн зөвшөөрөлт (УСНББОУС 27-г үзнэ үү); ба
- (к) Ашигт малтмалын олборлолт.

## Тодорхойлолт

11. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

**Арилжааны ажил гүйлгээ** гэдэг нь нэг байгууллага хөрөнгө буюу үйлчилгээг хүлээн авах, эсвэл өр төлбөрийг барагдуулах ба үүний хариуд ойролцоогоор тэнцүү үнэ цэнэ бүхий зүйлсийг (үндсэндээ мөнгө, бараа, үйлчилгээ буюу хөрөнгө ашиглуулах хэлбэрээр) нөгөө талд шууд өгдөг ажил гүйлгээг хэлнэ.

**Бодит үнэ цэнэ** гэдэг нь холбоогүй талуудын ажил гүйлгээгээр зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хооронд хөрөнгийг арилжих буюу өр төлбөрийг барагдуулж болох дүн юм.

**Арилжааны бус ажил гүйлгээ** нь арилжааны ажил гүйлгээнээс бусад ажил гүйлгээ юм. Арилжааны бус ажил гүйлгээнд, байгууллага



хариуд нь ойролцоогоор тэнцүү үнэ цэнэ бүхий зүйлийг шууд өгөхгүйгээр нөгөө талаас үнэ цэнэт зүйлийг хүлээн авах, эсвэл хариуд нь ойролцоогоор тэнцүү үнэ цэнэ бүхий зүйлийг шууд авахгүйгээр нөгөө талд үнэ цэнэт зүйлийг өгдөг.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь-д* дахин нийтэлсэн болно.

## Орлого

12. Орлого нь зөвхөн тухайн байгууллагын хүлээн авсан болон түүний данс тооцоогоор хүлээн авах эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн нийт орлогын гүйлгээг агуулсан байна. Засгийн газрын буюу засгийн газрын өөр нэг байгууллагын агент байдлаар, эсвэл бусад гуравдагч талын нэрийн өмнөөс цуглуулсан дүн, жишээлбэл, суурин утасны болон цахилгааны төлбөрийг тухайн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын нэрийн өмнөөс шуудангийн алба цуглуулах нь уг байгууллагад орох эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи биш бөгөөд хөрөнгийн өсөлт эсвэл өр төлбөрийн бууралт бий болгохгүй. Иймээс эдгээрийг орлогод оруулахгүй. Үүнтэй адилаар, агентын харилцааны хувьд эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн нийт орлогын гүйлгээ нь үндсэн оролцогчийн нэрийн өмнөөс цуглуулсан дүнг агуулах бөгөөд энэ нь тухайн байгууллагын цэвэр хөрөнгө/өмчийг нэмэгдүүлэх үр дүнгүй байна. Үндсэн оролцогчийн нэрийн өмнөөс цуглуулсан дүн нь орлого биш юм. Харин уг нийт орлогын гүйлгээг цуглуулах буюу хариуцан хөтөлсөний төлөө хүлээн авсан буюу авах аливаа шимтгэл нь орлого юм.
13. Санхүүжилтийн орлогын гүйлгээ, тухайлбал зээл нь (а) хөрөнгө ба өр төлбөрийн аль алинд адил тэнцүү өөрчлөлт оруулах, ба (б) цэвэр хөрөнгө/өмчид нөлөө үзүүлэхгүй учраас орлогын тодорхойлолтыг хангахгүй. Санхүүжилтийн орлогын гүйлгээг санхүүгийн байдлын тайланд шууд тусгах бөгөөд хөрөнгө, өр төлбөрийн үлдэгдэл дээр нэмдэг.

## Орлогын хэмжилт

14. **Орлогыг хүлээн авсан буюу хүлээн авах төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжинэ.**
15. Ажил гүйлгээнээс үүсэх орлогын дүнг тухайн байгууллага ба түүний хөрөнгө, үйлчилгээг худалдан авагч буюу хэрэглэгчийн хооронд байгуулсан гэрээгээр ихэвчлэн тодорхойлдог. Тухайн байгууллагын зөвшөөрсөн аливаа худалдааны болон тоо хэмжээний хөнгөлөлтөд хамаарах дүнг харгалзан тусгасан уг хүлээн авсан буюу хүлээн авах төлбөрийн бодит үнэ цэнээр орлогыг хэмжинэ.

16. Ихэнх тохиолдолд төлбөр нь мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө хэлбэртэй байх бөгөөд уг орлогын дүн нь хүлээн авсан буюу авах мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийн дүн байна. Гэвч мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийн орлогын гүйлгээг хойшлуулсан тохиолдолд уг төлбөрийн бодит үнэ цэнэ нь хүлээн авсан буюу авах мөнгөний нэрлэсэн дүнгээс бага байж болно. Жишээлбэл; байгууллага нь худалдан авагчид хүүгүй зээлээр авах эрх олгодог эсвэл тухайн бараа борлуулалтын төлбөр болгон зах зээлийн түвшнээс бага хүүтэй авлагын бичгийг уг худалдан авагчаас хүлээн авч болох юм. Ийм хэлцэл нь санхүүжилтийн ажил гүйлгээг зохих ёсоор орлон илэрхийлэх тохиолдолд, нуугдмал хүүний түвшинг ашиглан ирээдүйн бүх мөнгөн орлогыг дискаунтчилснаар тэрхүү төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлно. Нуугдмал хүүний түвшинг дараах аль нэг байдлаар илүү ойлгомжтой тодорхойлж болох юм:
- (а) Гаргагчийн зээлийн ижил үнэлэмж бүхий адилтгах хэрэглүүрийн давамгайлах хүүний түвшин; эсвэл
  - (б) Тухайн хэрэглүүрийн нэрлэсэн дүнг уг бараа, үйлчилгээний мөнгөн борлуулалтын одоогийн үнэтэй тэнцүү болтол дискаунтчилах хүүний түвшин.

Төлбөрийн бодит үнэ цэнэ ба нэрлэсэн дүнгийн хоорондох зөрүүг 33 ба 34-р параграфын дагуу хүүний орлого гэж хүлээн зөвшөөрнө.

17. Бараа, үйлчилгээг ижил шинж төрөл ба үнэ цэнэ бүхий бараа, үйлчилгээгээр арилжсан буюу солилцсон тохиолдолд уг арилжааг орлого бий болгох ажил гүйлгээ гэж үзэхгүй. Бэлтгэн нийлүүлэгчид нь тухайн нэг байршил дахь эрэлт хэрэгцээг цаг тухайд нь хангах үүднээс өөр өөр байршилд буй бараа материалаа харилцан солилцох буюу арилжих газрын тос, сүү гэх мэт хэрэглээний зүйлсийн хувьд ийм тохиолдол байнга үүсдэг. Ижил төсгүй бараа, үйлчилгээний хариуд барааг борлуулах буюу үйлчилгээ үзүүлэх тохиолдолд уг ажил гүйлгээг орлого бий болгох ажил гүйлгээ гэж үзнэ. Тухайн орлогыг хүлээн авсан бараа, үйлчилгээний бодит үнэ цэнээр хэмжих ба шилжүүлсэн аливаа мөнгө буюу мөнгөтэй адилтгах хөрөнгийн дүнгээр тохируулна. Хүлээн авсан бараа, үйлчилгээний бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадахгүй тохиолдолд орлогыг тухайн өгсөн бараа, үйлчилгээний бодит үнэ цэнээр орлогыг хэмжих ба шилжүүлсэн аливаа мөнгө буюу мөнгөтэй адилтгах хөрөнгийн дүнгээр тохируулна.

## **Ажил гүйлгээг тодорхойлох**

18. Энэ Стандарт дахь хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг ажил гүйлгээ бүрд ихэвчлэн тус тусад нь мөрддөг. Гэвч зарим нөхцөлд ажил гүйлгээний мөн чанарыг тусгахын тулд тухайн хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг нэг ажил гүйлгээний тусдаа тодорхойлж болох бүрэлдэхүүн хэсгүүдэд мөрдөх шаардлагатай болдог. Жишээлбэл; бүтээгдэхүүний үнэ нь дараагийн тайлант үеүдэд үзүүлэх үйлчилгээний хувьд хамааруулан тодорхойлж болох дүнг агуулдаг тохиолдолд тэрхүү дүнг хойшлуулж, уг үйлчилгээг үзүүлэх тайлант үеийн туршид орлого гэж хүлээн зөвшөөрнө. Харин

эсрэгээр, хэд хэдэн цуврал ажил гүйлгээг бүхэлд нь харгалзан үзэхгүйгээр түүний үр нөлөөг ойлгох боломжгүй тийм байдлаар хоорондоо холбоотой хоёр буюу хэд хэдэн ажил гүйлгээний хувьд уг хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хамтад нь хэрэглэнэ. Жишээлбэл; байгууллага нь бараагаа борлуулах ба мөн үүний хамтаар тухайн бараагаа дараа нь буцаан худалдан авах тусдаа хэлцлийг байгуулж болох юм. Ингэснээр уг ажил гүйлгээний гол үр нөлөө харилцан нөхөгдөж, бие биенийгээ үгүйсгэх бөгөөд энэ тохиолдолд тэрхүү хоёр ажил гүйлгээг хамтад нь авч үзнэ.

## Үйлчилгээ үзүүлэх

19. **Үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой ажил гүйлгээний үр дүнг найдвартай тооцоолж чадах тохиолдолд тайлангийн өдрөөрх уг ажил гүйлгээний иж бүрдлийн үе шатыг харгалзан лавлагаа болгосноор тэрхүү ажил гүйлгээнд хамаарах орлогыг хүлээн зөвшөөрнө. Дараах бүх нөхцөл хангагдсан тохиолдолд ажил гүйлгээний үр дүнг найдвартай тооцоолж чаддаг:**
- (а) **Орлогын дүнг найдвартай хэмжиж чадах;**
  - (б) **Ажил гүйлгээтэй холбоотой эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь тухайн байгууллагад орох нилээд их магадлалтай байх;**
  - (в) **Тухайн тайлангийн өдрөөрх уг ажил гүйлгээний иж бүрдэлтийн үе шатыг найдвартай хэмжиж чадах; ба**
  - (г) **Тухайн ажил гүйлгээний хувьд гарсан өртөг зардал ба уг ажил гүйлгээг дуусган иж бүрэн болгоход гарах өртөг зардлыг найдвартай хэмжиж чадах.**
20. Ажил гүйлгээний иж бүрдлийн үе шатыг лавлагаа болгосноор зөвшөөрөх орлогын хүлээн зөвшөөрөлтийг ихэвчлэн гүйцэтгэлийн хувийн жингийн арга гэж нэрлэдэг. Энэхүү аргын дагуу үйлчилгээг үзүүлсэн тухайн тайлант үеүдэд орлогыг хүлээн зөвшөөрдөг. Жишээлбэл; үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлж буй байгууллага нь тухайн тодорхой үнэлгээг гүйцэтгэсэн хэмжээгээр орлогыг хүлээн зөвшөөрнө. Ийм сууриар хийгдэх орлогын хүлээн зөвшөөрөлт нь тайлант үеийн туршид үзүүлсэн үйлчилгээ ба гүйцэтгэлийн хэмжээний талаархи ач холбогдолтой мэдээллээр хангадаг. УСНББОУС 11 нь мөн энэ сууриар орлого хүлээн зөвшөөрөхийг шаарддаг. Уг Стандартын шаардлагуудыг үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой ажил гүйлгээний орлого болон холбогдох зардлын хүлээн зөвшөөрөлтөнд ерөнхийдөө мөрдөх боломжтой байдаг.
21. Ажил гүйлгээтэй холбоотой эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь тухайн байгууллагад орох нилээд магадлалтай байх зөвхөн тийм тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрнө. Орлогод нэгэнт тусгасан дүнгийн цуглуулалтын хувьд тодорхойгүй байдал үүссэн тохиолдолд уг үл цуглуулагдах дүн буюу нөхөн төлөгдөх магадлалгүй болсон дүнг тэрхүү анх хүлээн зөвшөөрсөн орлогын тохируулга байдлаар биш, харин зардал гэж хүлээн зөвшөөрнө.

22. Байгууллага нь тухайн ажил гүйлгээний хувьд бусад талуудтай дараах зүйлсийг тохиролцсоны дараа ерөнхийдөө найдвартай тооцоолол хийх боломжтой болдог:

- (a) Талуудын үзүүлэх болон хүлээн авах үйлчилгээний талаархи тал тус бүрийн хууль ёсны эрх;
- (б) Арилжин солилцох төлбөр; ба
- (в) Төлбөрийг барагдуулах арга хэлбэр ба нөхцөл.

Санхүүгийн төсөвлөлтийн болон тайлагналын үр дүнтэй дотоод системтэй байх нь байгууллагын хувьд мөн ихэвчлэн зайлшгүй шаардлагатай байдаг. Үйлчилгээг гүйцэтгэхийн хирээр байгууллага нь орлогын тооцооллыг нягталж шалгах ба шаардлагатай бол засварлан өөрчилдөг. Ийм засвар өөрчлөлт хийх шаардлагатай байдал нь тухайн ажил гүйлгээний үр дүнг найдвартай тооцоолж чадахгүй гэдгийг заавал илэрхийлэх албагүй юм.

23. Ажил гүйлгээний иж бүрдлийн үе шатыг янз бүрийн аргаар тодорхойлж болох юм. Байгууллага нь гүйцэтгэсэн үйлчилгээг найдвартай хэмжих аргыг ашиглана. Ажил гүйлгээний шинж төрлөөс хамааран дараах аргуудыг ашиглаж болох юм:

- (a) Гүйцэтгэсэн ажлын судалгаа;
- (б) Гүйцэтгэх нийт үйлчилгээний хувийн жин байдлаар тухайн өдөр хүртэл гүйцэтгэсэн үйлчилгээ; эсвэл
- (в) Ажил гүйлгээний тооцоолсон нийт өртөгтэй харьцуулахад тухайн өдөр хүртэл гарсан өртөг зардлын хувийн жин. Зөвхөн тухайн өдөр хүртэл гүйцэтгэсэн үйлчилгээг илэрхийлэх өртөг зардлыг тэрхүү өдөр хүртэл гарсан өртөг зардалд тусган оруулна. Гүйцэтгэсэн буюу гүйцэтгэх үйлчилгээг зөвхөн илэрхийлэх өртөг зардлыг тухайн ажил гүйлгээний тооцоолсон нийт өртөгт тусган оруулна.

Үйлчлүүлэгчдээс хүлээн авсан явцын төлбөр ба урьдчилгаа нь гүйцэтгэсэн үйлчилгээг ямагт илэрхийлээд байдаггүй.

24. Үйлчилгээг тусгайлан заасан хугацааны туршид тодорхойгүй тооны үйлдлүүдээр гүйцэтгэдэг тохиолдолд тухайн иж бүрдлийн үе шатыг өөр бусад арга илүү сайн илэрхийлнэ гэсэн нотолгоо байхгүй л бол практик хэрэглээний зорилгын хувьд орлогыг тэрхүү тусгайлан заасан хугацааны туршид шулуун шугамын аргаар хүлээн зөвшөөрнө. Тусгайлан заасан нэг үйлдэл нь бусад аливаа үйлдлээс илүү чухал ач холбогдолтой тохиолдолд тэрхүү чухал үйлдлийг гүйцэтгэх хүртэл орлогын хүлээн зөвшөөрөлтийг хойшлуулна.

25. **Үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой ажил гүйлгээний үр дүнг найдвартай тооцоолж чадахгүй тохиолдолд хүлээн зөвшөөрсөн ба нөхөн төлөгдөх зөвхөн зардлын хэмжээгээр орлогыг хүлээн зөвшөөрнө.**

26. Ажил гүйлгээний эхний үе шатуудын явцад тухайн ажил гүйлгээний үр дүнг ихэвчлэн найдвартай тооцоолж чаддаггүй. Гэвч байгууллага нь тухайн гарсан ажил гүйлгээний өртөг зардлыг нөхөх нилээд их магадлалтай байж болно. Иймээс нөхөн төлөгдөхөөр хүлээгдэж буй зөвхөн гарсан өртөг зардлын хэмжээгээр орлогыг хүлээн зөвшөөрдөг. Ажил гүйлгээний үр дүнг найдвартай тооцоолж чадахгүй учраас ашиг хүлээн зөвшөөрөхгүй.
27. (а) ажил гүйлгээний үр дүнг найдвартай тооцоолж чадахгүй, ба (б) гарсан өртөг зардлыг нөхөх магадлал багатай тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд гарсан өртөг зардлыг зардал гэж хүлээн зөвшөөрнө. Гэрээний үр дүнг найдвартай тооцоолоход саад учруулж буй тодорхойгүй байдал арилсан тохиолдолд орлогыг 25-р параграфын дагуу биш, харин 19-р параграфын дагуу хүлээн зөвшөөрнө.

## **Бараа борлуулалт**

28. **Дараах бүх нөхцөл хангагдсан тохиолдолд бараа борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрнө:**
- (а) **Байгууллага нь барааны өмчлөлийн мэдэгдэхүйц эрсдэл ба өгөөжийг худалдан авагчид шилжүүлсэн;**
  - (б) **Байгууллага нь тухайн борлуулсан барааны өмчлөлтэй ихэвчлэн холбоотойгоор цаашдын удирдлагын оролцоо болон үр дүнтэй хяналтын аль алиныг хадгалан хариуцахаа больсон;**
  - (в) **Орлогын дүнг найдвартай хэмжиж чадах;**
  - (г) **Ажил гүйлгээтэй холбоотой эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь тухайн байгууллагад орох нилээд их магадлалтай байх; ба**
  - (д) **Тухайн жил гүйлгээний хувьд гарсан буюу гарах өртөг зардлыг найдвартай хэмжиж чадах.**
29. Өмчлөлийн мэдэгдэхүйц эрсдэл ба өгөөжийг худалдан авагчид тухайн байгууллага хэзээ шилжүүлсэн талаархи үнэлгээ нь уг ажил гүйлгээний нөхцөл байдлыг хянаж шалгахыг шаарддаг. Өмчлөлийн эрсдэл ба өгөөжийн шилжүүлэлт нь худалдан авагчид олгох хууль ёсны эрхийн шилжүүлэлт буюу эзэмшлийн шилжүүлэлттэй ихэнх тохиолдолд давхацдаг. Ихэнх борлуулалтын хувьд ийм тохиолдол үүсдэг. Харин өөр зарим тохиолдолд өмчлөлийн эрсдэл ба өгөөжийн шилжүүлэлт нь хууль ёсны эрхийн шилжүүлэлт буюу эзэмшлийн шилжүүлэлтээс өөр цаг хугацаанд хийгддэг.
30. Хэрэв байгууллага нь өмчлөлийн мэдэгдэхүйц эрсдлийг хадгалан үлддэг бол тухайн ажил гүйлгээ нь борлуулалт биш бөгөөд орлогыг хүлээн зөвшөөрөхгүй. Байгууллага нь өмчлөлийн мэдэгдэхүйц эрсдлийг олон арга замаар хадгалан үлдэж болно. Байгууллага нь өмчлөлийн

мэдэгдэхүйц эрсдэл ба өгөөжийг хадгалан үлдэж болох нөхцөл байдлуудын жишээ нь:

- (a) Байгууллага нь хэвийн баталгааны нөхцөлд үл хамаарах хангалтгүй гүйцэтгэлийн хувьд үүрэг хүлээдэг;
- (б) Тухайн нэг борлуулалтаас үүсэх орлогын хүлээн авалт нь тэрхүү барааны борлуулалтаас худалдан авагч орлого олох эсэхээс хамаарах болзошгүй хамаардаг (жишээлбэл; засгийн газрын хэвлэлийн үйл ажиллагаа нь сургалт боловсролын материалыг сургуулиудад борлуулалт ба буцаалт гэсэн аргаар түгээн хуваарилдаг);
- (в) Барааг угсарч суурилуулах нөхцөлтэйгээр ачуулдаг бөгөөд тэрхүү угсарч суурилуулалт нь тухайн байгууллагын хараахан гүйцэтгээгүй байгаа гэрээний чухал хэсэг болдог; ба
- (г) Худалдан авагч нь борлуулалтын гэрээнд тусгайлан заасан учир шалтгаанаар уг худалдан авалтаа цуцлах эрхтэй бөгөөд тухайн байгууллага нь тэрхүү буцаалтын магадлалын талаар мэдэхгүй байх.

31. Хэрэв байгууллага нь өмчлөлийн өчүүхэн эрсдлийг хадгалан үлддэг бол уг ажил гүйлгээ нь борлуулалт болох бөгөөд орлогыг хүлээн зөвшөөрнө. Жишээлбэл; борлуулагч нь авах дүнгийнхээ цуглуулагдах боломжит байдлыг зөвхөн хамгаалахын тулд тухайн барааны хууль ёсны эрхийг хадгалан үлдэж болох юм. Ийм тохиолдолд хэрэв байгууллага нь өмчлөлийн мэдэгдэхүйц эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн бол уг ажил гүйлгээ нь борлуулалт болох бөгөөд орлогыг хүлээн зөвшөөрнө. Өмчлөлийн зөвхөн өчүүхэн эрсдлийг байгууллага хадгалан үлдэх өөр нэг жишээ нь тухайн худалдан авагч сэтгэл ханамжгүй бол мөнгийг буцаан олгохоор санал болгодог борлуулалт байж болох юм. Энэ тохиолдолд борлуулагч нь ирээдүйн буцаалтыг найдвартай тооцоолж чадах бөгөөд өмнөх туршлага болон бусад холбогдох хүчин зүйлсэд үндэслэн тэрхүү буцаалтын хувьд өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг бол борлуулалт хийсэн хугацаанд орлогыг хүлээн зөвшөөрнө.

32. Тухайн ажил гүйлгээтэй холбоотой эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь байгууллагад орох нилээд их магадлалтай зөвхөн тийм тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрнө. Зарим тохиолдолд төлбөрийг хүлээн авах буюу тодорхойгүй байдал арилах хүртэл ийм магадлалгүй байж болно. Жишээлбэл; тухайн гэрээний нэг хэсэг байдлаар барааг нийлүүлэх өөр нэг байгууллагын чадвар, боломжоос орлого нь хамааралтай байж болох бөгөөд ингэж нийлүүлэх боломжтой эсэх талаар ямар нэг эргэлзээ байгаа бол үүнийг арилж, барааг нийлүүлэх хүртэл хүлээн зөвшөөрөлтийг хойшлуулж болно. Барааг нийлүүлсэн үед тодорхойгүй байдал арилах бөгөөд орлогыг хүлээн зөвшөөрнө. Орлогод нэгэнт тусгасан дүнгийн цуглуулалтын хувьд тодорхойгүй байдал үүссэн тохиолдолд уг үл цуглуулагдах дүн буюу нөхөн төлөгдөх магадлалгүй болсон дүнг тэрхүү анх хүлээн зөвшөөрсөн орлогын тохируулга байдлаар биш, харин зардал гэж хүлээн зөвшөөрнө.

## **Хүү, эрхийн шимтгэл, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт**

33. **Хүү, эрхийн шимтгэл, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг бий болгох тухайн байгууллагын хөрөнгийг бусдад ашиглуулснаар үүсэх орлогыг дараах тохиолдолд 34-р параграфт заасан нягтлан бодох бүртгэлийн хандлагыг ашиглан хүлээн зөвшөөрнө:**
- (а) **Ажил гүйлгээтэй холбоотой эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь тухайн байгууллагад орох нилээд их магадлалтай байх;**
  - (б) **Орлогын дүнг найдвартай хэмжиж чадах.**
34. **Дараах нягтлан бодох бүртгэлийн хандлагыг ашигласнаар орлогыг хүлээн зөвшөөрнө:**
- (а) **Хөрөнгийн үр ашигт өгөөжийг харгалзан цаг хугацаатай хувь тэнцүүлсэн сууриар хүүг хүлээн зөвшөөрнө;**
  - (б) **Холбогдох гэрээний мөн чанарын дагуу олсон хэмжээгээр эрхийн шимтгэлийг хүлээн зөвшөөрнө; ба**
  - (в) **Төлбөрийг хүлээн авах хувьцаа эзэмшигчийн болон байгууллагын эрхийг тогтоосон үед ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг хүлээн зөвшөөрнө.**
35. Хөрөнгийн үр ашигт өгөөж гэдэг нь тухайн хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн орлогын урсгалыг түүний анхны дансны үнэтэй тэнцүү болгон дискаунтчилахад шаардлагатай хүүний хувь хэмжээ юм. Хүүний орлого нь өрийн үнэт цаасны анхны дансны үнэ ба түүний дуусгавар болгох дүнгийн хоорондох аливаа хөнгөлөлт, урамшуулал буюу болон зөрүүгийн хорогдуулгын дүнг агуулсан байна.
36. Хүүтэй хөрөнгө оруулалтыг худалдан авахаас өмнө түүний төлөгдөөгүй хүү хуримтлагдсан тохиолдолд дараагийн тайлант үе дэх хүүний хүлээн авалтыг уг худалдан авалтын өмнөх ба дараах тайлант үеүдийн хооронд хуваарилна; зөвхөн тухайн худалдан авалтын дараах хэсгийг орлого гэж хүлээн зөвшөөрнө. Өмчийн үнэт цаасны ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг тухайн худалдан авалтын өмнөх цэвэр ашгаас зарласан тохиолдолд тэрхүү ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг уг үнэт цаасны өртгөөс хасна. Санамсаргүй тохиолдлын шинжтэйгээс өөр бусад сууриар ийм хуваарилалтыг хийхэд төвөгтэй байх тохиолдолд тухайн ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт нь уг өмчийн үнэт цаасны өртгийн нэг хэсгийн нөхөлт гэдэг нь илт тодорхой биш бол тэдгээрийг орлого гэж хүлээн зөвшөөрнө.
37. Газрын тосны эрхийн шимтгэл гэх мэт эрхийн шимтгэлийг холбогдох гэрээний нөхцлийн дагуу хуримтлуулдаг бөгөөд тэрхүү гэрээний мөн чанарыг харгалзан үзсэнээр орлогыг өөр бусад системтэй ба ул

үндэслэлтэй сууриар хүлээн зөвшөөрөх нь илүү тохиромжтой байхаас бусад тохиолдолд ихэвчлэн уг гэрээний сууриар хүлээн зөвшөөрнө.

38. Ажил гүйлгээтэй холбоотой эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь тухайн байгууллагад орох нилээд магадлалтай байх зөвхөн тийм тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрнө. Орлогод нэгэнт тусгасан дүнгийн цуглуулалтын хувьд тодорхойгүй байдал үүссэн тохиолдолд уг үл цуглуулагдах дүн буюу нөхөн төлөгдөх магадлалгүй болсон дүнг тэрхүү анх хүлээн зөвшөөрсөн орлогын тохируулга байдлаар биш, харин зардал гэж хүлээн зөвшөөрнө.

## Тодруулга

39. **Байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:**
- (a) Орлогын хүлээн зөвшөөрөлтийн хувьд мөрдсөн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үүн дотроо үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой ажил гүйлгээний иж бүрдлийн үе шатыг тодорхойлоход ашигласан аргууд;
  - (б) Тухайн тайлант үеийн туршид хүлээн зөвшөөрсөн орлогын гол ангилал нэг бүрийн дүн, үүн дотроо дараах зүйлсээс үүссэн орлого:
    - (i) Үйлчилгээ үзүүлэх;
    - (ii) Бараа борлуулалт;
    - (iii) Хүү;
    - (iv) Эрхийн шимтгэл; ба
    - (v) Ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт.
  - (в) Орлогын гол ангилал бүрт тусган оруулсан бараа буюу үйлчилгээний арилжаанаас үүссэн орлогын дүн.
40. Аливаа болзошгүй хөрөнгө ба болзошгүй өр төлбөрийн тодруулгын талаархи заавар удирдамжийг УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-өөс үзэж болно. Болзошгүй хөрөнгө ба болзошгүй өр төлбөр нь баталгаат зардал, хохирлын нэхэмжлэл, торгууль буюу боломжит алдагдал гэх мэт зүйлсээс үүсэж болно.

## Хүчин төгөлдөр болох хугацаа

41. Байгууллага нь энэхүү Стандартыг 2002 оны 7 дугаар сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2002 оны 7 дугаар сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.



- 41А. 2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-ийн үр дүнд 42-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед УСНББОУС 33-ыг мөрдсөн бол уг нэмэлт өөрчлөлтийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.
- 41Б. 2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 37, *Хамтын Хэлэлцээрийн үр дүнд 10(б) параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан*. Байгууллага нь УСНББОУС 37-г мөрдсөн үеэс уг нэмэлт өөрчлөлтийг дагаж мөрдөнө.
- 41В. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 2, 3-р параграфуудыг хассан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
42. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

## Дүгнэлтийн Үндэслэл

Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 9-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

**2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУС3-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 9-д хийсэн хянан засварлалт**

ДҮ1. УСНББОУС3 нь 2016 оны 4 дүгээр сард УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (а) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р* параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

## **Хэрэгжүүлэх заавар удирдамж**

*Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 9-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

ХЗУ1. Улсын секторын байгууллагууд нь арилжааны болон арилжааны бус ажил гүйлгээнээс орлого олдог. Энэ Стандарт нь зөвхөн арилжааны ажил гүйлгээнээс үүссэн орлогод хамаарна. Арилжааны ажил гүйлгээний орлого нь дараах зүйлсээс бий болдог:

- (а) Гуравдагч талд бараа борлуулах буюу үйлчилгээ үзүүлэх;
- (б) Засгийн газрын бусад агентлагуудад бараа борлуулах буюу үйлчилгээ үзүүлэх; ба
- (в) Хүү, эрхийн шимтгэл, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг бий болгох уг байгууллагын хөрөнгийг бусдад ашиглуулах.

ХЗУ2. Хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг тухайн тодорхой ажил гүйлгээнд мөрдөхөд дараах зүйлс нөлөөлж болно:

- (а) Өмчлөлийн мэдэгдэхүйц эрсдэл ба өгөөжийг байгууллага шилжүүлэх хугацааны агшинг тодорхойлж болох янз бүрийн улс орнуудын хууль. Иймээс хэрэгжүүлэх заавар удирдамжийн энэхүү хэсэг дэх жишээнүүдийг тухайн ажил гүйлгээ хийгдэх улс орны холбогдох хуулийн хамт унших шаардлагатай; ба
- (б) Төлбөр төлж байгаа болон орлого хүлээн авч буй байгууллагуудын хоорондох (гэрээний буюу бусад) харилцааны шинж төрөл (өөрөөр хэлбэл, орлогыг хүлээн авч буй байгууллага нь орлогыг хүлээн зөвшөөрөх хугацааны тодорхой агшинг нөгөө байгууллага хүлээн зөвшөөрч болох юм).

### **Үйлчилгээ үзүүлэх**

*Орон байраар хангах*

ХЗУ3. Орон байраар хангаснаар үүсэх түрээсийн орлогыг тухайн хөлслөх гэрээний нөхцлүүдийн дагуу орлого олсон үед хүлээн зөвшөөрнө.

*Сургуулийн тээвэр*

ХЗУ4. Сургуулийн тээврийн хэрэгслээр үйлчилсний төлөө зорчигчдоос нэхэмжлэх тээврийн хөлснөөс үүсэх орлогыг тухайн тээвэрлэлтийг хийснээр хүлээн зөвшөөрнө.

*Төлбөртэй замын удирдлага*

ХЗУ5. Төлбөртэй замын менежментийн орлогыг тухайн замын ашиглалтанд үндэслэн орлого олсон гэж хүлээн зөвшөөрнө.

*Шүүх ажиллагаа*

ХЗУ6. Шүүх ажиллагаанаас үүсэх орлогыг уг шүүх үйл явцын иж бүрдлийн үе шатыг лавлагаа болгосноор эсвэл шүүх хурал болсон тайлант үеүдэд үндэслэн хүлээн зөвшөөрнө.

*Байгууламж, хөрөнгө, үйлчилгээний менежмент*

ХЗУ7. Байгууламж, хөрөнгө, үйлчилгээний менежментээс үүсэх орлогыг тухайн менежментийн үйлчилгээг үзүүлсэх гэрээний хугацаанд хүлээн зөвшөөрнө.

*Шинжлэх ухаан ба технологийн судалгаа*

ХЗУ8. Шинжлэх ухаан ба технологийн судалгаа хийх гэрээний дагуу үйлчлүүлэгчдээс хүлээн авсан орлогыг тухайн төслүүдийн иж бүрдлийн үе шатыг лавлагаа болгосноор хүлээн зөвшөөрнө.

*Суурилуулах хөлс*

ХЗУ9. Барааны борлуулалтыг дагалдах ба ингэснээр тухайн барааг борлуулсан үед хүлээн зөвшөөрдөг байхаас бусад тохиолдолд суурилуулалтын хөлсийг уг суурилуулалтын иж бүрдлийн үе шатыг лавлагаа болгосноор орлого гэж хүлээн зөвшөөрнө.

*Бүтээгдэхүүний үнэд багтсан үйлчилгээний хөлс*

ХЗУ10. Бүтээгдэхүүний борлуулалтын үнэ нь дараагийн үйлчилгээний (жишээлбэл; программ хангамжийн борлуулалтын дараах дэмжлэг ба бүтээгдэхүүний сайжруулан баяжуулалт) тодорхойлж болох дүнг агуулсан тохиолдолд уг дүнг хойшлуулж, тэрхүү үйлчилгээг үзүүлэх тайлант үеийн туршид орлого гэж хүлээн зөвшөөрнө. Тухайн хойшлуулсан дүн нь гэрээний дагуу үзүүлэхээр хүлээгдэж буй үйлчилгээний өртөг болон тэрхүү үйлчилгээгээр олох зохих өгөөжийг нөхөхөөр байна.

*Даатгалын агентын шимтгэл*

ХЗУ11. Цаашид үйлчилгээ үзүүлэхийг агентаас шаардахгүй, даатгалын агентын хүлээн авсан буюу авах шимтгэлийг тухайн холбогдох даатгалын гэрээний хүчин төгөлдөр эхлэлийн эсвэл шинэчлэлийн өдөр уг агент нь орлого гэж хүлээн зөвшөөрнө. Харин даатгалын гэрээний хугацаанд цаашид үйлчилгээ үзүүлэхийг уг агентаас шаардах нилээд их магадлалтай тохиолдолд тэрхүү шимтгэл буюу түүний хэсгийг хойшлуулж, тухайн даатгалын гэрээ хүчин төгөлдөр байх тайлант үеийн туршид орлого гэж хүлээн зөвшөөрнө.

*Санхүүгийн үйлчилгээний хураамж*

ХЗУ12. Санхүүгийн үйлчилгээний хураамжийн хувьд орлогын хүлээн зөвшөөрөлт нь (а) ийм хураамж авах зорилго, ба (б) аливаа холбогдох санхүүгийн

хэрэглүүрийн нягтлан бодох бүртгэлийн сууриас хамаардаг. Санхүүгийн үйлчилгээний хураамжийн нэр утга нь тухайн үзүүлсэн үйлчилгээний шинж төрөл ба мөн чанарыг илэрхийлэхгүй байж болно. Иймээс санхүүгийн хэрэглүүрийн үр ашигт өгөөжийн салшгүй нэг хэсэг болох хураамж, үйлчилгээ үзүүлснээр авах хураамж, чухал үйлдлийг гүйцэтгэснээр авах хураамжийг өөр хооронд нь ялган зааглах шаардлагатай байдаг.

(a) **Санхүүгийн хэрэглүүрийн үр ашигт өгөөжийн салшгүй нэг хэсэг болох хураамж**

Ийм хураамжийг үр ашигт хүүний хувь хэмжээний тохируулга гэж ерөнхийдөө үздэг. Гэвч бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрснөөр тухайн санхүүгийн хэрэглүүрийг бодит үнэ цэнээр хэмждэг тохиолдолд уг хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрөх үед хураамжийг орлого гэж хүлээн зөвшөөрнө.

(i) *УСНББОУС 29-ийн дагуу “ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн” санхүүгийн хөрөнгө гэж ангилдагаас бусад, санхүүгийн хөрөнгийг бий болгох буюу худалдан авахтай холбоотойгоор тухайн байгууллагын хүлээн авсан үүсгэлтийн хураамж*

Ийм хураамж нь зээлдэгчийн санхүүгийн нөхцөл байдлыг үнэлэх, баталгаа, барьцаа болон бусад аюулгүй байдлын арга хэмжээг үнэлэх ба бүртгэх, санхүүгийн хэрэглүүрийн нөхцлийг хэлэлцэн тохирох, баримт бичгийг бэлтгэж боловсруулах, ажил гүйлгээг дуусгаж, хаах гэх мэт үйл ажиллагааны нөхөн төлбөрийг багтаасан байж болно. Эдгээр хураамж нь уг үр дүн болох санхүүгийн хэрэглүүртэй холбоотой оролцоог бий болгох үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг бөгөөд тэдгээрийг холбогдох ажил гүйлгээний зардлын хамтаар (УСНББОУС 29-д тодорхойлсон) хойшлуулж, үр ашигт хүүний хувь хэмжээний тохируулга байдлаар хүлээн зөвшөөрнө.

(ii) *Зээл олгох баталгаа нь УСНББОУС 29-ийн цар хүрээнд хамаарахгүй тохиолдолд зээлийг үүсгэхийн тулд уг байгууллагын хүлээн авсан баталгааны хураамж.*

Байгууллага нь тодорхой нэг зээлийн хэлцлийг байгуулах нилээд их магадлалтай бөгөөд зээл олгох баталгаа нь УСНББОУС 29-ийн цар хүрээнд хамаарахгүй тохиолдолд уг хүлээн авсан баталгааны хураамжийг тухайн санхүүгийн хэрэглүүрийн худалдан авалттай холбоотой байнгын оролцооны нөхөн төлбөр гэж үзэх бөгөөд тэдгээрийг холбогдох ажил гүйлгээний зардлын хамтаар (УСНББОУС 29-д тодорхойлсон) хойшлуулж, үр ашигт хүүний хувь хэмжээний тохируулга байдлаар хүлээн зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь зээл олгохгүйгээр уг баталгааны хугацаа дууссан бол хураамжийг тэрхүү хугацаа дууссан өдрөөр орлого гэж хүлээн

зөвшөөрнө. УСНББОУС 29-ийн цар хүрээнд хамаарах, зээл олгох баталгааг үүсмэл хэрэглүүр гэж тайлагнах бөгөөд бодит үнэ цэнээр нь хэмжинэ.

- (iii) *Хорогдуулсан өртгөөр нь хэмждэг санхүүгийн өр төлбөрийг гаргаснаар хүлээн авах үүсгэлтийн хураамж*

Ийм хураамж нь санхүүгийн өр төлбөртэй холбоотой оролцоог бий болгох үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг юм. Санхүүгийн өр төлбөрийг “ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн” гэж ангилдаггүй тохиолдолд уг хүлээн авсан үүсгэлтийн хураамжийг холбогдох ажил гүйлгээний гарсан зардлын хамтаар (УСНББОУС 29-д тодорхойлсон) тухайн санхүүгийн өр төлбөрийн анхны дансанд үнэд тусган оруулж, үр ашигт хүүний хувь хэмжээний тохируулга байдлаар хүлээн зөвшөөрнө. Байгууллага нь санхүүгийн өр төлбөрийн үр ашигт хүүний хувь хэмжээний салшгүй нэг хэсэг болох хураамж ба зардлыг хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ гэх мэт үйлчилгээ үзүүлэх эрхтэй холбоотой үүсгэлтийн хураамж ба ажил гүйлгээний зардлаас тусад нь ялгаж үзнэ.

**(б) Үйлчилгээг үзүүлснээр авах хураамж**

- (i) *Зээл олгох үйлчилгээний хураамж*

Зээл олгох үйлчилгээний хувьд байгууллагын авах хураамжийг тухайн үйлчилгээг үзүүлснээр орлого гэж хүлээн зөвшөөрнө.

- (ii) *УСНББОУС 29-ийн цар хүрээнд хамаардаггүй зээл олгох баталгааны хураамж*

Тодорхой нэг зээлийн хэлцлийг байгуулах магадлал багатай бөгөөд зээл олгох баталгаа нь УСНББОУС 29-ийн цар хүрээнд хамаарахгүй тохиолдолд уг зээл олгох баталгааны хураамжийг тухайн баталгааны хугацаанд цаг хугацаатай хувь тэнцүүлсэн сууриар орлого гэж хүлээн зөвшөөрнө. УСНББОУС 29-ийн цар хүрээнд хамаарах, зээл олгох баталгааг үүсмэл хэрэглүүр гэж тайлагнах бөгөөд бодит үнэ цэнээр нь хэмжинэ.

- (iii) *Хөрөнгө оруулалтын менежментийн хөлс*

Хөрөнгө оруулалтын менежментийн хөлсийг тухайн үйлчилгээг үзүүлснээр орлого гэж хүлээн зөвшөөрнө.

Хөрөнгө оруулалтын менежментийн гэрээний аюулгүй байдлыг хангахад шууд хамааралтай өсөн нэмэгдэх зардлыг тусдаа тодорхойлж, найдвартай хэмжиж чадах ба тэдгээр нь нөхөгдөх нилээд их магадлалтай тохиолдолд түүнийг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө. УСНББОУС 29-д заасанчлан, ийм өсөн нэмэгдэх зардал нь хэрэв байгууллага тухайн хөрөнгө

оруулалтын менежментийн гэрээний аюулгүй байдлыг хангаагүй бол гарахааргүй байсан зардал юм. Хөрөнгө нь хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлснээр үүсэх өгөөжийг хүртэх уг байгууллагын гэрээний эрхийг илэрхийлэх бөгөөд холбогдох орлогыг тухайн байгууллага хүлээн зөвшөөрөхийн хирээр түүнийг хорогдуулна. Хэрэв байгууллага нь хөрөнгө оруулалтын менежментийн гэрээнүүдийн багцтай бол тэдгээр гэрээний нөхөгдөх байдлыг багцаар нь үнэлж болно.

Санхүүгийн үйлчилгээний зарим гэрээ нь нэг буюу хэд хэдэн санхүүгийн хэрэглүүрийг үүсгэх ба хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны аль алиныг агуулсан байдаг. Жишээлбэл; өмчийн үнэт цааснуудын багцын менежменттэй уялдсан, сар тутмын хадгаламжийн урт хугацаат гэрээ. Ийм гэрээгээр хангагч нь тухайн санхүүгийн хэрэглүүрийг үүсгэхтэй холбоотой ажил гүйлгээний зардлыг тэрхүү хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээг үзүүлэх эрхийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон зардлаас ялган зааглана.

(в) **Чухал үйлдлийг гүйцэтгэснээр авах хураамж**

Доорх жишээнд дурдсанчлан, чухал үйлдлийг гүйцэтгэсэн үед хураамжийг орлого гэж хүлээн зөвшөөрнө.

(i) *Үйлчлүүлэгчид оролцооны хувийг хуваарилсаны хураамж*

Оролцооны хувийг хуваарилсан үед хураамжийг орлого гэж хүлээн зөвшөөрнө.

(ii) *Зээлдэгч ба хөрөнгө оруулагчийн хооронд зээлийг зохион байгуулсаны төлөөх байршуулалтын хураамж*

Зээлийг зохион байгуулсан үед хураамжийг орлого гэж хүлээн зөвшөөрнө.

(iii) *Зээлийн түншлэлийн хураамж*

Зээл олгох ажиллагааг зохион байгуулдаг бөгөөд зээлийн багцын тодорхой нэг хэсгийг өөртөө авч үлддэггүй (эсвэл бусад оролцогчдын эрсдэлтэй адил, зэрэгцүүлэгдэх эрсдлийн хувьд тухайн үр ашигт хүүний хувиар тооцогдох тодорхой зарим хэсгийг авч үлддэг) байгууллагын хүлээн авсан зээлийн түншлэлийн хураамж нь түншлэлийн үйлчилгээний нөхөн төлбөр юм. Ийм хураамжийг уг түншлэлийг хийсэн үед орлого гэж хүлээн зөвшөөрнө.

*Оролцох эрхийн хураамж*

ХЗУ13. Урлагийн тоглолт, цайллага болон бусад тусгай арга хэмжээнээс үүсэх орлогыг тухайн үйл явдал болох үед хүлээн зөвшөөрнө. Олон үйл явдалд оролцох захиалгыг борлуулсан тохиолдолд тухайн үйл явдал тус бүрд үзүүлэх үйлчилгээний хэмжээг тусгасан тийм сууриар уг хураамжийг үйл явдал нэг бүрд хуваарилна.

*Сургалтын төлбөр*

ХЗУ14. Сургалтын хугацаанд орлогыг хүлээн зөвшөөрнө.

*Элсэлтийн, оролтын болон гишүүнчлэлийн хураамж*

ХЗУ15. Орлогын хүлээн зөвшөөрөлт нь үзүүлсэн үйлчилгээний шинж төрлөөс хамаардаг. Хураамж нь зөвхөн гишүүнчлэлийн эрхийн төлбөр бөгөөд бусад бүх бараа, үйлчилгээний үнийг тусдаа төлдөг, эсвэл жилийн тусдаа захиалга хийдэг бол тухайн хураамжийн цуглуулалт ихээхэн тодорхойгүй байхаас бусад тохиолдолд түүнийг орлого гэж хүлээн зөвшөөрнө. Тухайн хураамжийн төлөө гишүүн нь гишүүнчлэлийн хугацааны туршид үзүүлэх үйлчилгээ буюу хэвлэлээр хангагдах эсвэл гишүүн бус этгээдээс нэхэмжлэх дүнгээс бага үнээр бараа, үйлчилгээг худалдан авах эрхтэй байдаг бол тэрхүү хүртэх үр өгөөжийн хугацаа, шинж төрөл, үнэ цэнийг тусгах тийм сууриар уг хураамжийг орлого гэж хүлээн зөвшөөрнө.

*Франчайз буюу концессын төлбөр*

ХЗУ16. Франчайз буюу концессийн төлбөр нь анхны болон дараагийн үйлчилгээ, тоног төхөөрөмж, бусад биет хөрөнгө, ноу-хауны нийлүүлэлтийг агуулсан байж болно. Иймээс тухайн төлбөрийг нэхэмжилсэн зорилгыг тусган илэрхийлэх сууриар франчайз буюу концессын төлбөрийг орлого гэж хүлээн зөвшөөрнө. Франчайз буюу концессын төлбөрийг хүлээн зөвшөөрөхөд дараах аргууд тохиромжтой байдаг:

**(а) Тоног төхөөрөмж ба бусад биет хөрөнгийн нийлүүлэлт**

Борлуулсан хөрөнгийн бодит үнэ цэнэд үндэслэсэн дүнг уг зүйлсийг хүргэсэн буюу эрх шилжсэн үед орлого гэж хүлээн зөвшөөрнө.

**(б) Анхны ба дараагийн үйлчилгээний нийлүүлэлт**

Анхны төлбөрийн нэг хэсэг эсвэл тусдаа төлбөр эсэхээс үл хамааран байнгын үйлчилгээ үзүүлэхэд зориулсан төлбөрийг тухайн үйлчилгээг үзүүлсэн хэмжээгээр орлого гэж хүлээн зөвшөөрнө. Тусдаа төлбөр нь байнгын үйлчилгээний өртөг зардал ба зохих өгөөжийг нөхөхөөргүй байх тохиолдолд тухайн байнгын үйлчилгээг нөхөх ба түүний зохих өгөөжөөр хангахад хүрэлцэхүйц хэмжээний уг анхны төлбөрийн хэсгийг хойшлуулж, тэрхүү үйлчилгээг үзүүлсэн хэмжээгээр орлого гэж хүлээн зөвшөөрнө.



(в) **Франчайз буюу концессын байнгын төлбөр**

Гэрээгээр олгосон байнга ашиглах эрх буюу тухайн гэрээний хугацаанд үзүүлэх бусад үйлчилгээний төлөө ногдуулсан төлбөрийг уг үйлчилгээг үзүүлсэн эсвэл эрхийг ашигласан хэмжээгээр орлого гэж хүлээн зөвшөөрнө.

(г) **Агентын ажил гүйлгээ**

Франчайз өмчлөгч нь мөн чанарын хувьд франчайз ашиглагчийн агентын үүргийг гүйцэтгэдэг ажил гүйлгээ нь франчайз өмчлөгч ба франчайз ашиглагчийн хооронд хийгдэж болно. Жишээлбэл; франчайз өмчлөгч нь хангамжийн зүйлсийг захиалж, тэдгээрийг ямар нэг ашиггүйгээр тухайн франчайз ашиглагчид хүргэх ажлыг хариуцан зохион байгуулдаг байж болно. Ийм ажил гүйлгээ нь орлого үүсгэхгүй.

*Хэрэглэгчид тусгайлан зориулсан программ хангамжийг хөгжүүлэн боловсруулсаны төлбөр*

ХЗУ17. Хэрэглэгчид тусгайлан зориулсан программ хангамжийн хөгжүүлэн боловсруулалтаас олох төлбөрийг тухайн хөгжүүлэлтийн иж бүрдлийн үе шат, үүн дотроо нийлүүлэлтийн дараах үйлчилгээний дэмжлэг болгон үзүүлэх үйлчилгээний иж бүрдлийг харгалзан орлого гэж хүлээн зөвшөөрнө.

**Бараа борлуулалт**

*“Нэхэмжлэх ба Эзэмших” борлуулалт, энд худалдан авагчийн хүсэлтээр нийлүүлэлтийг хойшлуулдаг боловч тухайн худалдан авагч нь өмчлөх эрхийг авсан ба нэхэмжлэлийг зөвшөөрсөн байдаг.*

ХЗУ18. Дараах тохиолдолд худалдан авагч нь өмчлөх эрхийг авсан үед орлогыг хүлээн зөвшөөрнө:

- (а) *Нийлүүлэлтийг хийх нилээд их магадлалтай;*
- (б) *Тухайн зүйл гар дээр бэлэн байгаа бөгөөд борлуулалтыг хүлээн зөвшөөрсөн үед тухайн худалдан авагчид хүргэхэд зориулан ялган тодорхойлж, бэлэн болгосон;*
- (в) *Худалдан авагч нь уг хойшлогдсон хүргэлтийн зааварчилгааг тусгайлан өгдөг; ба*
- (г) *Төлбөрийн хэвийн нөхцлийг хэрэглэдэг.*

Нийлүүлэх хугацаанд тухайн барааг зүгээр л худалдан авах буюу үйлдвэрлэх санаа зорилготой байгаа тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрөхгүй.

ХЗУ19. Нөхцөлтэй ачуулсан бараа

(a) **Суурилуулалт ба шалгалт**

Худалдан авагч нь хүргэлтийг хүлээн зөвшөөрч, суурилуулалт ба шалгалтын ажил дууссан үед ихэвчлэн орлогыг хүлээн зөвшөөрдөг. Гэвч дараах тохиолдолд худалдан авагч нь хүргэлтийг хүлээн зөвшөөрсөн даруйд орлогыг хүлээн зөвшөөрнө:

- (i) Суурилуулах үйл явц нь мөн чанарын хувьд энгийн хялбар байх; эсвэл
- (ii) Гэрээний үнийг зөвхөн эцэслэн тодорхойлох зорилгоор шалгалтыг гүйцэтгэдэг байх.

(б) **Худалдан авагч нь буцаах хязгаарлагдмал эрхтэй байхаар хэлцэл хийсэн үеийн зөвшөөрөл**

Буцаалт хийх боломж тодорхой бус бол тухайн ачуулалтыг худалдан авагч албан ёсоор хүлээн зөвшөөрсөн эсвэл барааг хүргэсэн ба түүнээс татгалзах эрхтэй хугацаа дууссан үед орлогыг хүлээн зөвшөөрнө.

(в) **Хүлээн авагч (худалдан авагч) нь ачуулагч (борлуулагч)-ийн өмнөөс барааг борлуулах хариуцлага хүлээдэг агентын борлуулалт**

Хүлээн авагч нь барааг гуравдагч талд борлуулсан тохиолдолд ачуулагч нь орлогыг хүлээн зөвшөөрнө.

(г) **Хүргэлтийн мөнгөн борлуулалт**

Хүргэлт хийгдэж, борлуулагч буюу түүний агент нь мөнгийг хүлээн авсан үед орлогыг хүлээн зөвшөөрнө.

*Хадгалан хойшлуулах борлуулалт, энэ нь цуврал хэсэгчилсэн төлбөрүүдийн хамгийн сүүлчийн төлбөрийг худалдан авагч төлсөн зөвхөн тэр үед барааг нийлүүлдэг борлуулалт юм.*

ХЗУ20. Ийм борлуулалтын орлогыг барааг хүргэсэн үед хүлээн зөвшөөрнө. Гэвч тухайн бараа гар дээр бэлэн байгаа бөгөөд худалдан авагчид хүргэхэд зориулан түүнийг ялган тодорхойлж, бэлэн болгосон үед ийм ихэнх борлуулалт хэрэгждэг гэдгийг туршлагаар харуулсан тохиолдолд мэдэгдэхүйц их мөнгийг хүлээн авснаар орлогыг хүлээн зөвшөөрч болох юм.

*Одоогоор бараа материал байдлаар эзэмшээгүй байгаа барааны нийлүүлэлтийн хувьд төлбөр (буюу хэсэгчилсэн төлбөр)-ийг урьдчилан хүлээн авсан захиалга. Жишээлбэл; барааг одоогоор үйлдвэрлэж байгаа буюу гуравдагч талаас тухайн худалдан авагчид шууд хүргэнэ.*

ХЗУ21. Барааг худалдан авагчид хүргэсэн үед орлогыг хүлээн зөвшөөрнө.

*Борлуулах ба буцаан худалдан авах гэрээ (свопын ажил гүйлгээнээс бусад), энд борлуулагч нь уг борлуулсан барагаа хожим буцаан худалдан авахыг зөвшөөрдөг буюу борлуулагч нь буцаан худалдан авах эрх бүхий дуудах опционтой, эсвэл худалдан авагч нь тухайн барааг буцаан худалдан авахыг борлуулагчаас шаардах, буцаах эрхтэй опционтой байх.*

ХЗУ22. Борлуулагч нь мөн чанарын хувьд өмчлөлийн эрсдэл ба өгөөжийг худалдан авагчид шилжүүлсэн, иймээс орлогыг хүлээн зөвшөөрөх эсэхийг тодорхойлохын тулд тухайн гэрээний нөхцлүүдийг шинжлэн үзэх шаардлагатай. Хэдийгээр хууль ёсны эрх шилжсэн боловч борлуулагч нь өмчлөлийн эрсдэл ба өгөөжийг хадгалан үлдсэн тохиолдолд уг ажил гүйлгээ нь санхүүжилтийн арга хэмжээ болох бөгөөд орлого бий болгохгүй.

*Дистрибьютор, дилер буюу буцаан борлуулах бусад талууд гэх мэт зуучлагч талуудад хийсэн борлуулалт*

ХЗУ23. Ийм борлуулалтаас үүссэн орлогыг тухайн өмчлөлийн эрсдэл ба өгөөж шилжсэн үед ерөнхийдөө хүлээн зөвшөөрдөг. Гэвч худалдан авагч нь мөн чанарын хувьд агентын үүрэг гүйцэтгэж байвал тухайн борлуулалтыг агентын борлуулалт гэж үзнэ.

*Хэвлэл ба ижил төсөөтэй зүйлсийн захиалга*

ХЗУ24. Хамрагдах зүйлс нь нэг тайлант үеэс дараагийн тайлант үед ижил үнэ цэнэтэй байдаг тохиолдолд уг зүйлсийг тараан илгээх тайлант үеийн туршид орлогыг шулуун шугамын аргаар хүлээн зөвшөөрнө. Нэг тайлант үеэс дараагийн тайлант үед тухайн зүйлсийн үнэ цэнэ хувьсан өөрчлөгддөг тохиолдолд уг захиалгад хамрагдах бүх зүйлсийн тооцоолсон нийт борлуулалтын үнэ цэнэд тэрхүү тараан илгээсэн зүйлсийн борлуулалтын үнэ цэнийг харьцуулсан сууриар орлогыг хүлээн зөвшөөрнө.

*Хэсэгчилсэн төлбөртэй борлуулалт, энд төлбөр нь хэсэгчлэн төлөгдөх авлага байна.*

ХЗУ25. Борлуулалтын үнэд хамаарах ба хүүг хассан дүнгээр тухайн борлуулалтын өдөр орлогыг хүлээн зөвшөөрнө. Борлуулалтын үнэ нь уг төлбөрийн өнөөгийн үнэ цэнэ бөгөөд тэрхүү хэсэгчлэн төлөгдөх авлагыг нуугдмал хүүний түвшнээр дискаунтчилснаар төлбөрийн өнөөгийн үнэ цэнийг тодорхойлдог. Уг нуугдмал хүүний түвшинг харгалзан тооцдог хүүний элементийг цаг хугацааны хувь тэнцүүлсэн суурийн дагуу олсон хэмжээгээр орлого гэж хүлээн зөвшөөрнө.

*Үл хөдлөх хөрөнгийн борлуулалт*

ХЗУ26. Хууль ёсны эрх нь худалдан авагчид шилжсэн үед орлогыг ихэвчлэн хүлээн зөвшөөрдөг. Гэвч зарим улс оронд үл хөдлөх хөрөнгийн хууль ёсны эрх шилжихээс өмнө түүний тэгш шударга оролцооны эрх нь худалдан авагчид шилжиж болно, ингэснээр өмчлөлийн эрсдэл ба өгөөж нь энэ үед шилждэг. Ийм тохиолдолд хэрэв борлуулагч нь тухайн гэрээний дагуу цаашид гүйцэтгэх мэдэгдэхүйц ажил байхгүй бол орлогыг хүлээн зөвшөөрөх нь тохиромжтой байж болно. Борлуулагч нь тэгш шударга оролцооны эрх эсвэл хууль ёсны эрхийг шилжүүлсний дараа аливаа мэдэгдэхүйц ажлыг гүйцэтгэх үүрэгтэй байх аль ч тохиолдолд тэрхүү ажлыг гүйцэтгэсэн хэмжээгээр орлогыг хүлээн зөвшөөрнө. Жишээлбэл; барьж байгуулах ажлыг хараахан дуусгаагүй байгаа барилга буюу бусад байгууламж.

ХЗУ27. Зарим тохиолдолд борлуулагчийн байнгын оролцоотойгоор үл хөдлөх хөрөнгийг борлуулж болох бөгөөд ингэснээр өмчлөлийн эрсдэл ба өгөөжийг шилжүүлдэггүй. Жишээ нь, (а) дуудах болон буцаах опцион бүхий борлуулах ба буцаан худалдан авахгэрээ, (б) борлуулагч нь тухайн үл хөдлөх хөрөнгө тодорхой хугацааны туршид түрээслэгдэх талаар баталгаа өгсөн эсвэл тусгайлан заасан хугацааны туршид уг худалдан авагчийн хөрөнгө оруулалтын өгөөжид баталгаа өгсөн гэрээ. Ийм тохиолдолд борлуулагчийн байнгын оролцооны шинж төрөл ба хэмжээ нь уг ажил гүйлгээг хэрхэн тайлагнахыг тодорхойлдог. Үүнийг борлуулалт, санхүүжилт, лизинг буюу өөр бусад байдлаар ашиг хуваах хэлцэл байдлаар тайлагнаж болно. Хэрэв үүнийг борлуулалт гэж тайлагнавал тухайн борлуулагчийн байнгын оролцооны улмаас орлогын хүлээн зөвшөөрөлтийг хойшлуулж болох юм.

ХЗУ28. Борлуулагч нь төлбөрийн арга хэрэгсэл болон төлбөр төлөх уг худалдан авагчийн баталгааны талаархи нотлох баримтыг мөн харгалзан үзэх шаардлагатай. Жишээлбэл; хүлээн авсан төлбөрийн нийт дүн, үүн дотроо худалдан авагчийн анхны урьдчилгаа төлбөр буюу түүний төлөх байнгын төлбөрүүд нь төлбөрийг барагдуулах тухайн худалдан авагчийн баталгааны хувьд хангалттай нотлох баримт бүрдүүлж чадахгүй тохиолдолд зөвхөн хүлээн авсан мөнгөний хэмжээгээр орлогыг хүлээн зөвшөөрнө.

**Хүү, эрхийн шимтгэл, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт**

*Лицензийн төлбөр ба эрхийн шимтгэл*

ХЗУ29. Байгууллагын хөрөнгийг (худалдааны тэмдэг, патент, программ хангамж, хөгжмийн зохиогчийн эрх, бичлэгийн эх хувь, кино хальс гэх мэт) ашигласны төлөө төлсөн төлбөр болон эрхийн шимтгэлийг ихэвчлэн гэрээний мөн чанарын дагуу хүлээн зөвшөөрдөг. Практикт, үүнийг тухайн гэрээний хугацаанд шулуун шугамын аргаар тооцож болно. Жишээлбэл; лиценз ашиглагч нь тодорхой нэг технологийг тогтоосон хугацаанд ашиглах эрхтэй байдаг.

ХЗУ30. Тогтмол төлбөрөөр олгох эрхийн шилжүүлэлт эсвэл үл цуцлагдах гэрээний дагуу (а) эрхийг үнэ төлбөргүй ашиглах боломжийг тухайн лиценз ашиглагчид зөвшөөрдөг, ба (б) лиценз олгогч нь гүйцэтгэх ямар нэг үлдсэн үүрэггүй байдаг, үл буцаагдах баталгаа нь мөн чанарын хувьд борлуулалт юм. Жишээлбэл; лиценз олгогч нь нийлүүлэлтийн дараа ямар нэг үүрэггүй байх программ хангамжийг ашиглах лицензийн гэрээ. Өөр нэг жишээ нь; лиценз олгогч нь дистрибьюторт хяналт тавихгүй ба билетийн кассын борлуулалтаас цаашид орлого авахгүй тохиолдолд киног зах зээлд гаргаж үзүүлэх эрх олголт. Ийм тохиолдолд борлуулсан үед орлогыг хүлээн зөвшөөрнө.

ХЗУ31. Зарим тохиолдолд лицензийн төлбөр буюу эрхийн шимтгэлийг хүлээн авах эсэх нь ирээдүйн үйл явдлын гарч тохиолдолтоос болзошгүй хамаардаг. Ийм тохиолдолд төлбөр буюу эрхийн шимтгэлийг хүлээн авах нилээд их магадлалтай, ихэвчлэн тухайн үйл явдал гарч тохиолдсон үед л орлогыг хүлээн зөвшөөрдөг.

### **Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт**

*Байгууллага нь үндсэн оролцогч эсвэл агентын үүрэг гүйцэтгэдэг эсэхийг тодорхойлох (2010 оны нэмэлт өөрчлөлт)*

ХЗУ32. “Агентын харилцааны хувьд эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн нийт орлогын гүйлгээ нь үндсэн оролцогчийн нэрийн өмнөөс цуглуулсан дүнг агуулах бөгөөд энэ нь тухайн байгууллагын цэвэр хөрөнгө/өмчийг нэмэгдүүлэх үр дүнгүй байна. Үндсэн оролцогчийн нэрийн өмнөөс цуглуулсан дүн нь орлого биш юм. Харин уг нийт орлогын гүйлгээг цуглуулах буюу хариуцан хөтөлсөний төлөө хүлээн авсан буюу авах аливаа шимтгэл нь орлого юм” гэж 12-р параграфт заасан байдаг. Байгууллага нь үндсэн оролцогч эсвэл агентын үүрэг гүйцэтгэж буй эсэхийг тодорхойлохдоо холбогдох бүх баримт материал болон нөхцөл байдлыг харгалзан үзэж, шүүн тунгаалт хийх шаардлагатай байдаг.

ХЗУ33. Бараа борлуулалт буюу үйлчилгээ үзүүлэлттэй холбоотой мэдэгдэхүйц эрсдлийг хүлээх ба өгөөжийг хүртэх тохиолдолд уг байгууллага нь үндсэн оролцогчийн үүрэг гүйцэтгэнэ. Байгууллага нь үндсэн оролцогчийн үүрэг гүйцэтгэж буй гэдгийг илэрхийлэх шинж тэмдэгүүдэд дараах зүйлс хамаарна:

- (а) Байгууллага нь бараа, үйлчилгээг худалдан авагчид нийлүүлэх буюу захиалгыг биелүүлэх үндсэн үүрэг хариуцлагатай байх. Жишээлбэл; худалдан авагчийн захиалсан буюу худалдан авсан бараа, үйлчилгээний хүлээн зөвшөөрөгдөх байдлын талаар хариуцлага хүлээх;
- (б) Байгууллага нь худалдан авагчийн захиалгын өмнө буюу дараа, тээвэрлэлтийн явцад эсвэл буцаалтын хувьд бараа материалын эрсдлийг хүлээдэг байх;

- (в) Байгууллага нь үнийг шууд буюу шууд бусаар тухайлбал, нэмэлт бараа, үйлчилгээ нийлүүлснээр тогтоох бүрэн эрхтэй байх; ба
- (г) Байгууллага нь тухайн худалдан авагчаас авах авлагын хувьд худалдан авагчийн зээлийн эрсдлийг хүлээдэг байх.

ХЗУ34. Бараа борлуулалт буюу үйлчилгээ үзүүлэлттэй холбоотой мэдэгдэхүйц эрсдлийг хүлээдэггүй ба өгөөжийг хүртдэггүй тохиолдолд уг байгууллага нь агентын үүрэг гүйцэтгэнэ. Тухайн байгууллага агентын үүрэг гүйцэтгэж буй гэдгийг илэрхийлэх нэг шинж нь түүний олох дүнг урьдчилан тодорхойлдог явдал юм. Жишээлбэл; ажил гүйлгээ бүрд тогтмол төлбөртэй байх эсвэл тухайн худалдан авагчаас нэхэмжилсэн дүнгийн тогтоосон хувийн жингээр илэрхийлэх.

## НББОУС 18-ТАЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 9, *Арилжааны Ажил Гүйлгээний Орлого*-ыг НББОУС 18, *Орлого*-оос үндсэндээ бэлтгэсэн. УСНББОУС 9 ба НББОУС 18-ын хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- УСНББОУС 9-ийн гарчиг нь НББОУС 18-ын гарчгаас өөр бөгөөд энэхүү ялгаатай байдал нь арилжааны бус ажил гүйлгээний орлогыг УСНББОУС 9-д авч үзэхгүй гэдгийг тодруулж байна.
- УСНББОУС 9-д хэрэглэсэн “орлого” /revenue/ нэр томъёоны тодорхойлолт нь НББОУС 18-д хэрэглэсэн “орлого” /revenue/ нэр томъёоны тодорхойлолттой төсөөтэй. Гол ялгаатай тал бол НББОУС 18 дахь тодорхойлолт нь ердийн үйл ажиллагаанд хамаардаг явдал юм.
- УСНББОУС 9 нь зарим тохиолдолд НББОУС 18-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь УСНББОУС 9 дэх “цэвэр хөрөнгө/өмч” гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. НББОУС 18 дахь адилтгах нэр томъёо нь “өмч” юм.

## УСНББОУС 10–ХЭТ ИНФЛЯЦИТАЙ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЕИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) 29, *Хэт Инфляцитай Эдийн Засгийн Үеийн Санхүүгийн Тайлагнал* (1994 онд дахин засварласан)-аас үндсэндээ бэлтгэсэн болно. НББОУС 29-өөс авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон ЕС4М 6ХН, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)  
Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.



## УСНББОУС 10-ХЭТ ИНФЛЯЦИТАЙ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЕИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

### УСНББОУС-ын түүх

Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

УСНББОУС 10, Хэт Инфляцитай Эдийн Засгийн Үеийн Санхүүгийн Тайлагнал-ыг 2001 оны 7 дугаар сард гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 10-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл (2017 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2011-ийн Сайжруулалтууд (2011 оны 10 дугаар сард гаргасан)
- УСНББОУС 4, Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө (2006 оны 12 дугаар сард гаргасан)
- УСНББОУС-ын Сайжруулалтууд (2010 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС-ын Сайжруулалтууд (2010 оны 11 дүгээр сард гаргасан)

### УСНББОУС 10-ын нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт

Өөрчлөгдсөн параграф	Хэрхэн өөрчилсөн	Юугаар өөрчилсөн
1-р параграфын дээд талын гарчиг	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
1	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
1А	Нэмэлт өөрчлөлт-Өмнө байсан 1-р параграфыг 1А гэж дугаарласан	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
1	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 4, 2006 оны 12-р сар

ХЭТ ИНФЛЯЦИТАЙ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЕИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

2	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
3	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
11	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 4, 2006 оны 12-р сар
17	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар
18	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар
20	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 4, 2006 оны 12-р сар
22	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
26	Хассан	УСНББОУС 4, 2006 оны 12-р сар
28	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
29	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
33	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 4, 2006 оны 12-р сар
36	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 4, 2006 оны 12-р сар
38А	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар
38Б	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
38В	Шинэ	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
38Г	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
38Д	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
39	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар

2001 оны 7 дугаар сар

**УСНББОУС 10–ХЭТ ИНФЛЯЦИТАЙ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЕИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ**

**АГУУЛГА**

---

	Параграф
Зорилго	1
Цар хүрээ	1А-6
Тодорхойлолт	7
Санхүүгийн тайлангийн дахин илэрхийлэлт	8-34
Санхүүгийн байдлын тайлан	14-26
Санхүүгийн үр дүнгийн тайлан	27
Цэвэр мөнгөн байдлын олз, гарз	28-29
Мөнгөн гүйлгээний тайлан	30
Харгалзах үзүүлэлтүүд	31
Нэгтгэсэн санхүүгийн тайлан	32-33
Үнийн ерөнхий индексийн сонголт ба хэрэглээ	34
Хэт инфляци зогссон эдийн засаг	35
Тодруулга	36-37
Хүчин төгөлдөр болох хугацаа	38-39
Дүгнэлтийн үндэслэл	
Үлгэрчилсэн жишээ	
НББОУС 29-тэй харьцуулалт	

## ХЭТ ИНФЛЯЦИТАЙ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЕИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 10, *Хэт Инфляцитай Эдийн Засгийн Үеийн Санхүүгийн Тайлагнал*-ыг 1-39-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 10-ыг түүний зорилгын агуулга, Дүгнэлтийн Үндэслэл, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

1. Энэ Стандартын зорилго бол бүртгэлийн валют нь хэт инфляцитай эдийн засгийн үеийн валют байх аливаа байгууллагын нэгтгэсэн болон бие даасан санхүүгийн тайлан дахь нягтлан бодох бүртгэлийн хандлагыг тодорхойлоход оршино. Эдийн засаг хэт инфляцитай байхаа больсон үеийн нягтлан бодох бүртгэлийн хандлагыг энэ Стандартад мөн тусгайлан заасан.

## Цар хүрээ

- 1А. **Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь анхдагч санхүүгийн тайландаа, түүнчлэн бүртгэлийн валют нь хэт инфляцитай эдийн засгийн үеийн валют байх аливаа байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.**
2. [Хассан]
3. [Хассан]
4. Хэт инфляцитай эдийн засгийн үед үйл ажиллагааны үр дүн ба санхүүгийн байдлыг дахин илэрхийлэхгүйгээр тухайн орон нутгийн валютаар тайлагнах нь ач холбогдолгүй юм. Өөр өөр цаг хугацаанд, түүнчлэн нягтлан бодох бүртгэлийн нэг тайлант үеийн дотор гарч тохиолдсон ажил гүйлгээ ба бусад үйл явдлуудаас үүссэн дүнгүүдийн зэрэгцүүлэлт нь төөрөгдөлд хүргэхүйц тийм хувь хэмжээгээр мөнгөний худалдан авах чадвар буурч байдаг.
5. Энэ Стандарт нь хэт инфляци үүссэн гэж үзэхэд хүргэх үнэмлэхүй дүнг тогтоохгүй. Энэ Стандартын дагуу санхүүгийн тайланг хэзээ дахин илэрхийлэх шаардлагатай эсэхийг тогтоох нь шүүн тунгаалтын асуудал юм. Хэт инфляци үүссэнийг илэрхийлэх улс орны эдийн засгийн шинж байдлуудад дараах зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:
  - (а) Ард түмэн нь өөрийн эд баялагийг мөнгөн бус хөрөнгөөр эсвэл харьцангуй тогтвортой гадаад валютаар хадгалахыг эрхэмлэдэг байх. Худалдан авах чадварыг хадгалахын тулд эзэмшиж буй дотоодын валютаар нэн даруй хөрөнгө оруулалт хийдэг байх;
  - (б) Ард түмэн нь мөнгөн дүнг дотоодын валютаар бус харин харьцангуй тогтвортой гадаад валютаар харгалзан үздэг байх. Үнийг мөн ийм гадаад валютаар тогтоох;
  - (в) Хэдийгээр зээлийн хугацаа богино байлаа ч гэсэн зээлээр борлуулалт ба худалдан авалт нь тухайн зээлийн хугацааны туршид худалдан авах чадварт гарахаар хүлээгдэж буй алдагдлыг нөхөх үнээр тооцогдох;
  - (г) Хүүний түвшин, цалин хөлс ба үнэ нь үнийн индекстэй холбогдсон байх;

- (д) Сүүлийн гурван жилийн инфляцийн хуримтлагдсан түвшин нь 100 хувьд ойртох буюу түүнээс давж гарах.
6. Хэт инфляцитай эдийн засгийн үеийн валютаар тайлагнаж буй бүх байгууллагууд нь уг тайлагналын өдрөөс эхлэн энэ Стандартыг мөрдөхийг зохистой гэж үзнэ. Гэхдээ тайлагнах уг валютын хамаарах улс оронд хэт инфляци үүссэн гэдгийг тогтоосон тухайн тайлант үеийн эхнээс энэ Стандартыг байгууллагын санхүүгийн тайланд мөрдөнө.

## Тодорхойлолт

7. **Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:**

**Хөрөнгийн дансны үнэ** гэдэг нь аливаа хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнэ бууралтын гарзыг хассаны дараах тухайн хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрч байгаа дүн юм.

**Өр төлбөрийн дансны үнэ** гэдэг нь өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрч байгаа дүн юм.

**Мөнгөн бус зүйлс** гэдэг нь мөнгөн зүйлсээс бусад зүйлс юм.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д дахин нийтэлсэн болно.

## Санхүүгийн тайлангийн дахин илэрхийлэлт

8. Үнэ нь улс төр, эдийн засаг, нийгмийн тусгай буюу ерөнхий янз бүрийн олон хүчин зүйлсийн үр дүнд цаг хугацааны явцад өөрчлөгдөж байдаг. Эрэлт, нийлүүлэлтийн өөрчлөлт, технологийн өөрчлөлт гэх мэт тусгай хүчин зүйлс нь үнэ нэг нэгнээсээ үл хамааран мэдэгдэхүйц хэмжээгээр өсөх эсвэл буурахад хүргэж болох юм. Түүнчлэн ерөнхий хүчин зүйлс нь үнийн ерөнхий түвшний өөрчлөлтөнд, ингэснээр мөнгөний ерөнхий худалдан авах чадварын өөрчлөлтөнд хүргэж болно.
9. Хэт инфляцитай эдийн засгийн үед санхүүгийн тайланг тухайн тайлант үеийн эцэст үйлчилж буй хэмжилтийн нэгжээр илэрхийлсэн зөвхөн тийм тохиолдолд уг санхүүгийн тайлан нь ач холбогдолтой байна. Иймээс хэт инфляцитай эдийн засгийн үеийн валютаар тайлагнаж буй байгууллагуудын анхдагч санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө. Энэ Стандартаар шаардсан мэдээллийг тухайн дахин илэрхийлээгүй санхүүгийн тайланд нэмэлт гүйцээлт болгон толилуулахыг зөвшөөрөхгүй. Мөн түүнчлэн, дахин илэрхийлэлтээс өмнөх уг санхүүгийн тайланг тусдаа толилуулахыг дэмжихгүй.

10. Улсын секторын олон байгууллагууд нь төсөвтэй харьцуулахын тулд холбогдох төсвийн мэдээллийг өөрсдийн санхүүгийн тайланд тусган оруулдаг. Ийм тохиолдолд төсвийн мэдээллийг мөн энэхүү Стандартын дагуу дахин илэрхийлэх хэрэгтэй.
11. **Бүртгэлийн валют нь хэт инфляцитай эдийн засгийн үеийн валют байх байгууллагын санхүүгийн тайланг тухайн тайлант үеийн эцэст үйлчилж буй хэмжилтийн нэгжээр илэрхийлнэ. УСНББОУС 1-ээр шаардсан өмнөх тайлант үеийн харгалзах үзүүлэлтүүд болон түүнээс өмнөх тайлант үеүдийн аливаа мэдээллийг тухайн тайлант үеийн эцэст үйлчилж буй хэмжилтийн нэгжээр бас илэрхийлнэ. Зэрэгцүүлэгдэх дүнгүүдийг толилуулгын өөр валютаар илэрхийлэх энэхүү зорилгын хувьд УСНББОУС 4, *Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө*-ний 47(б) ба 48-р параграфыг дагаж мөрдөнө.**
12. **Цэвэр мөнгөн байдлын олз, гарзыг санхүүгийн үр дүнгийн тайланд тусад нь толилууна.**
13. Энэ Стандартын дагуу хийх санхүүгийн тайлангийн дахин илэрхийлэлт нь зарим горимуудыг, түүнчлэн шүүн тунгаалт хэрэглэхийг шаарддаг. Эдгээр горимууд болон шүүн тунгаалтыг нэг тайлант үеэс нөгөө тайлант үед тууштай хэрэглэх нь уг дахин илэрхийлсэн санхүүгийн тайлан дахь дүнгүүдийн нарийн оновчтой байдлаас илүү чухал ач холбогдолтой юм.

#### **Санхүүгийн байдлын тайлан**

14. Тайлант үеийн эцэст үйлчилж буй хэмжилтийн нэгжээр харахан илэрхийлээгүй байгаа санхүүгийн байдлын тайлан дахь дүнгүүдийг үнийн ерөнхий индекс ашиглан дахин илэрхийлнэ.
15. Мөнгөн зүйлс нь тухайн тайлант үеийн эцэст үйлчилж буй мөнгөн нэгжээр аль хэдийн илэрхийлэгдсэн байдаг тул мөнгөн зүйлсийг дахин илэрхийлэхгүй. Мөнгөн зүйлс гэдэг нь эзэмшиж буй мөнгө, түүнчлэн мөнгөөр хүлээн авах эсвэл мөнгөөр төлөгдөх зүйлс юм.
16. Индексжүүлсэн бонд, индексжүүлсэн зээл гэх мэт үнийн өөрчлөлтийн хэлцэлд хамаарах хөрөнгө, өр төлбөрийн тухайн тайлант үеийн эцэс дэх эргэлтэнд байгаа дүнг тодорхойлохын тулд уг хэлцлийн дагуу тэдгээр хөрөнгө, өр төлбөрт тохируулга хийдэг. Дахин илэрхийлсэн санхүүгийн байдлын тайланд эдгээр зүйлсийг энэхүү тохируулсан дүнгээр тусгана.
17. Бусад бүх хөрөнгө, өр төлбөр нь мөнгөн бус зүйлс юм. Зарим мөнгөн бус зүйлс нь цэвэр боломжит үнэ цэнэ, бодит үнэ цэнэ гэх мэт тухайн тайлант үеийн эцэст үйлчилж буй дүнгээр бүртгэгдсэн байх тул тэдгээрийг дахин илэрхийлэхгүй. Бусад бүх мөнгөн зүйлсийн бус хөрөнгө, өр төлбөрийг дахин илэрхийлнэ.
18. Ихэнх мөнгөн бус зүйлсийг өртгөөр буюу өртгөөс элэгдлийг хассан дүнгээр бүртгэдэг; өөрөөр хэлбэл, ийм зүйлс нь тэдгээрийн худалдан

авалтын өдөр үйлчилж буй дүнгээр илэрхийлэгдсэн байдаг. Худалдан авалтын өдрөөс тухайн тайлант үеийн эцэс хүртэлх хугацаан дахь үнийн ерөнхий индексийн өөрчлөлтөөр уг зүйлийн түүхэн өртөг ба хуримтлагдсан элэгдлийг үржүүлснээр зүйл тус бүрийн хувьд тэдгээрийн дахин илэрхийлсэн өртөг буюу дахин илэрхийлсэн өртгөөс элэгдлийг хассан дүнг тодорхойлно. Жишээлбэл; үндсэн хөрөнгө, түүхий эд материал, бараа, гүүдвил, патент, худалдааны тэмдэг болон адилтгах хөрөнгүүдийг тэдгээрийн худалдан авалтын өдрөөс эхлэн дахин илэрхийлнэ. Дуусаагүй үйлдвэрлэл ба бэлэн бүтээгдэхүүнийг тэдгээрийн худалдан авалтын өртөг болон хувиргалтын зардал гарсан өдрөөс эхлэн дахин илэрхийлнэ.

19. Үндсэн хөрөнгийн зүйлсийн худалдан авалтын өдрийн талаархи дэлгэрэнгүй бүртгэл байхгүй эсвэл тэдгээрийг тооцоолох боломжгүй байж болох юм. Ийм цөөн ховор тохиолдолд дахин илэрхийлэлтийн суурь үндэслэл болгон эдгээр зүйлсийн үнэ цэнийн талаархи хараат бус мэргэжлийн үнэлгээг энэхүү Стандартыг мөрдөх эхний тайлант үед ашиглах шаардлагатай байж болно.
20. Энэ Стандартаар шаардсаны дагуу үндсэн хөрөнгийг дахин илэрхийлэх тухайн тайлант үеүдэд хамаарах үнийн ерөнхий индекс тодорхойгүй байж болох юм. Ийм тохиолдолд тухайлбал, бүртгэлийн валют ба харьцангуй тогтвортой гадаад валютын хоорондох ханшийн өөрчлөлтөнд үндэслэн хийсэн тооцооллыг ашиглах шаардлагатай байж болно.
21. Зарим мөнгөн бус зүйлсийг тэдгээрийн худалдан авалтын өдөр эсвэл санхүүгийн байдлын тайлангийн өдрөөс өөр өдөр үйлчилж буй дүнгээр бүртгэсэн байдаг. Жишээлбэл; үндсэн хөрөнгийг өмнөх тодорхой нэг өдрөөр дахин үнэлсэн байж болно. Энэ тохиолдолд уг дахин үнэлгээний өдрөөс эхлэн дансны үнийг дахин илэрхийлнэ.
22. Мөнгөн бус зүйлийн дахин илэрхийлсэн дүнгийн үнэ цэнэ буурсан ба түүнийг бууруулах хэрэгтэй эсэхийг тодорхойлохын тулд байгууллага нь УСНББОУС 21, *Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт* эсвэл УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-д заасан холбогдох үнэ цэнийн бууралтын сорилыг мөрдөнө. Жишээлбэл; үндсэн хөрөнгө, гүүдвил, патент, худалдааны тэмдгийн дахин илэрхийлсэн дүнг тэдгээрийн нөхөгдөх дүн буюу нөхөгдөх үйлчилгээний дүн, бараа материалын дахин илэрхийлсэн дүнг тэдгээрийн цэвэр боломжит үнэ цэнэ буюу одоогийн орлуулалтын өртгийн аль тохиромжтой хүртэл бууруулна. Өмчийн аргаар тайлагнагдсан санхүүжигч нь хэт инфляцитай эдийн засгийн үеийн валютаар тайлангаа бэлтгэдэг байж болох юм. Ийм санхүүжигчийн цэвэр хөрөнгө/өмч болон ашиг, алдагдалд тухайн хөрөнгө оруулагчийн эзлэх хувь оролцоог тооцохын тулд уг санхүүжигчийн санхүүгийн байдлын тайлан болон санхүүгийн үр дүнгийн тайланг энэхүү Стандартын дагуу дахин илэрхийлнэ. Тухайн санхүүжигчийн дахин илэрхийлсэн санхүүгийн тайланг гадаад валютаар толилуулдаг тохиолдолд түүнийг хаалтын ханшаар хөрвүүлнэ.



23. Инфляцийн үр нөлөөг ихэвчлэн зээлийн өртөгт оруулан хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ зээлээр санхүүжүүлсэн капитал зарлагыг дахин илэрхийлэх ба тухайн нэг тайлант үеийн инфляцийг нөхөж буй зээлийн өртгийн хэсгийг капиталжуулахын аль аль нь тохиромжтой биш юм. Иймээс зээлийн өртгийн тэрхүү хэсгийг тухайн өртөг гарсан тайлант үед зардал болгон хүлээн зөвшөөрнө.
24. Байгууллага нь илт тодорхой хүүний зардал гаргахгүйгээр төлбөрийг хойшлуулахыг зөвшөөрсөн хэлцлийн дагуу хөрөнгийг худалдан авч болох юм. Хүүний дүнг төсөөлөн тооцох практик боломжгүй тохиолдолд ийм хөрөнгийг худалдан авалтын өдрөөс биш, харин төлбөр хийсэн өдрөөс эхлэн дахин илэрхийлнэ.
25. Энэ Стандартыг мөрдсөн анхны тайлант үеийн эхэн дэх хуримтлагдсан ашиг/алдагдал ба аливаа дахин үнэлгээний нэмэгдлээс бусад цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тэдгээр бүрэлдэхүүн хэсгүүдийн хувь нийлүүлэн оруулсан буюу бусад байдлаар нэмэгдүүлсэн өдрөөс эхлэн үнийн ерөнхий индекс ашигласнаар дахин илэрхийлнэ. Өмнөх тайлант үеүдэд үүссэн аливаа дахин үнэлгээний нэмэгдлийг устгана. Дахин илэрхийлсэн хуримтлагдсан ашиг/алдагдал нь уг дахин илэрхийлсэн санхүүгийн байдлын тайлан дахь бусад бүх дүнгээр тодорхойлогдоно.
26. Анхны тайлант үеийн эцэст, түүнчлэн дараагийн тайлант үеүдэд цэвэр хөрөнгө/өмчийн бүх бүрэлдэхүүн хэсгүүдийг уг анхны тайлант үеийн эхнээс эсвэл үүнээс хойш хувь нийлүүлсэн бол тэрхүү өдрөөс эхлэн үнийн ерөнхий индекс ашигласнаар дахин илэрхийлнэ. Цэвэр хөрөнгө/өмчид тухайн тайлант үеийн туршид орсон өөрчлөлт хөдөлгөөнийг УСНББОУС 1-ийн дагуу толилуулна.

#### **Санхүүгийн үр дүнгийн тайлан**

27. Энэ Стандарт нь санхүүгийн үр дүнгийн тайлангийн бүх зүйлсийг тухайн тайлант үеийн эцэст үйлчилж буй хэмжилтийн нэгжээр илэрхийлэхийг шаарддаг. Иймээс орлого, зардлын зүйлсийг тухайн санхүүгийн тайланд анх бүртгэсэн өдрүүдээс эхлэн үнийн ерөнхий индексийн өөрчлөлтийг ашигласнаар бүх дүнгүүдийг дахин илэрхийлэх шаардлагатай.

#### **Цэвэр мөнгөн байдлын олз, гарз**

28. Инфляцитай тайлант үед мөнгөн зүйлсийн өр төлбөрөөсөө илүү давсан мөнгөн зүйлсийн хөрөнгөтэй байгууллага нь тухайн хөрөнгө, өр төлбөр үнийн түвшинтэй холбоогүй байх тэр хэмжээгээр худалдан авах чадвараа алддаг бол эсрэгээр, мөнгөн зүйлсийн хөрөнгөөсөө илүү давсан мөнгөн зүйлсийн өр төлбөртэй байгууллага нь худалдан авах чадвараа нэмэгдүүлдэг. Энэхүү цэвэр мөнгөн байдлын олз, гарз нь мөнгөн зүйлсийн бус хөрөнгийн, хуримтлагдсан ашиг, алдагдал болон санхүүгийн үр дүнгийн тайлан дахь зүйлсийн дахин илэрхийлэлт, түүнчлэн индексжүүлсэн хөрөнгө, өр төлбөрийн тохируулгаас бий болох зөрүү

байдлаар үүсэж болох юм. Мөнгөн зүйлсийн хөрөнгө ба мөнгөн зүйлсийн өр төлбөрийн хоорондох зөрүүгийн тухайн тайлант үеийн жинэлсэн дундаж дүнг үнийн ерөнхий индексийн өөрчлөлтөөр үржүүлснээр уг олз, гарзыг тооцоолж болно.

29. Цэвэр мөнгөн байдлын олз, гарзыг санхүүгийн үр дүнгийн тайланд тусган оруулна. Үнийн өөрчлөлтийн хэлцэлд хамаарах тэдгээр хөрөнгө, өр төлбөрт 16-р параграфын дагуу хийсэн тохируулгыг уг цэвэр мөнгөн байдлын олз, гарзаас хасаж, цэвэр дүнгээр тооцно. Хөрөнгө оруулсан буюу зээлдэн авсан мөнгө сантай холбоотой хүүний орлого, хүүний зардал, гадаад валютын ханшийн зөрүү гэх мэт санхүүгийн үр дүнгийн тайлангийн бусад зүйлс нь цэвэр мөнгөн байдалтай бас холбоотой байдаг. Хэдийгээр ийм зүйлсийг тусад нь тодруулдаг боловч хэрэв тэдгээрийг санхүүгийн үр дүнгийн тайланд цэвэр мөнгөн байдлын олз, гарзын хамт толилуулвал ач холбогдолтой байж болох юм.

### **Мөнгөн гүйлгээний тайлан**

30. Энэ Стандарт нь мөнгөн гүйлгээний тайлан дахь бүх зүйлсийг тухайн тайлант үеийн эцэст үйлчилж буй хэмжилтийн нэгжээр илэрхийлэхийг шаарддаг.

### **Харгалзах үзүүлэлтүүд**

31. Зэрэгцүүлэгдэх санхүүгийн тайлангуудыг тухайн тайлант үеийн эцэст үйлчилж буй хэмжилтийн нэгжээр толилуулахын тулд өмнөх тайлант үеийн харгалзах үзүүлэлтүүдийг түүхэн өртгийн арга хандлагад эсвэл одоогийн өртгийн арга хандлагад үндэслэсэн эсэхээс үл хамааран тэдгээрийг үнийн ерөнхий индексээр дахин илэрхийлдэг. Өмнөх үеүдэд хамаарах тодруулсан мэдээллийг мөн тухайн тайлант үеийн эцэст үйлчилж буй хэмжилтийн нэгжээр илэрхийлнэ. Зэрэгцүүлэгдэх дүнгүүдийг толилуулгын өөр валютаар илэрхийлэх энэхүү зорилгын хувьд УСНББОУС 4-ийн 47(б) ба 48-р параграфыг дагаж мөрдөнө.

### **Нэгтгэсэн санхүүгийн тайлан**

32. Хэт инфляцитай эдийн засгийн үеийн валютаар тайлагнадаг, хяналт тавигч байгууллага нь мөн хэт инфляцитай эдийн засгийн үеийн валютаар тайлагнадаг, хяналтанд буй байгууллагуудтай байж болох юм. Хяналт тавигч байгууллагын бэлтгэдэг нэгтгэсэн санхүүгийн тайланд тэдгээр хяналтанд буй байгууллагуудыг тусган оруулахын өмнө тухайн хяналтанд буй байгууллагын тайлагнадаг валютанд хамаарах улс орны үнийн ерөнхий индексийг ашигласнаар тийм аливаа хяналтанд буй байгууллагуудын санхүүгийн тайланг дахин илэрхийлэх шаардлагатай байдаг. Ийм хяналтанд буй байгууллага нь гадаад дахь хяналтанд буй байгууллага байх тохиолдолд түүний дахин илэрхийлсэн санхүүгийн тайланг хаалтын ханшаар хөрвүүлнэ. Хэт инфляцитай эдийн засгийн үеийн валютаар тайлагнадаггүй, хяналтанд буй байгууллагуудын санхүүгийн тайланг УСНББОУС 4-ийн дагуу тайлагнана.

33. Хэрэв тайлант үеийн эцэс нь өөр байх санхүүгийн тайлангуудыг нэгтгэвэл, мөнгөн зүйлс эсвэл мөнгөн бус зүйлс гэдгээс үл хамааран бүх зүйлсийг тухайн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн өдөр үйлчилж буй хэмжилтийн нэгжээр дахин илэрхийлэх шаардлагатай.

#### **Үнийн ерөнхий индексийн сонголт ба хэрэглээ**

34. Энэ Стандартын дагуу санхүүгийн тайланг дахин илэрхийлэлт нь худалдан авалтын ерөнхий чадварын өөрчлөлтийг тусгасан үнийн ерөнхий индекс ашиглахыг шаарддаг. Тухайн нэг эдийн засгийн үеийн валютаар тайлагнаж буй бүх байгууллагууд нь мөн нэг ижил индекс ашиглах хэрэгтэй гэж үздэг.

#### **Хэт инфляци зогссон эдийн засаг**

35. Эдийн засаг нь хэт инфляцитай байхаа больсон бөгөөд байгууллага нь энэ Стандартын дагуу санхүүгийн тайланг бэлтгэж, толилуулахаа зогсоох тохиолдолд уг өмнөх тайлант үеийн эцэст үйлчилж буй хэмжилтийн нэгжээр илэрхийлсэн дүнгүүдийг түүний дараагийн санхүүгийн тайлан дахь дансны үнийн хувьд суурь үндэслэл болно гэж үзнэ.

#### **Тодруулга**

36. **Дараах зүйлсийг тодруулна:**
- (а) Санхүүгийн тайлан ба өмнөх тайлант үеүдийн харгалзах үзүүлэлтийг уг бүртгэлийн валютын ерөнхий худалдан авах чадварын өөрчлөлтийн хувьд дахин илэрхийлсэн бөгөөд ингэснээр эдгээр нь тухайн тайлант үеийн эцэст үйлчилж буй хэмжилтийн нэгжээр илэрхийлэгдсэн талаархи тодруулга; ба
  - (б) Тухайн тайлант үеийн эцэс дэх үнийн индексийн тодорхойлолт ба түвшин, түүнчлэн уг тайлант үед болон өмнөх тайлант үеийн туршид энэхүү индексэд орсон өөрчлөлт.
37. Энэ Стандартаар шаардсан тодруулгууд нь инфляцийн үр нөлөөг тухайн санхүүгийн тайланд тусгах суурийг тодорхой болгоход зайлшгүй шаардлагатай байдаг. Эдгээр нь мөн уг суурь болон холбогдох дүнгүүдийг ойлгоход ач холбогдолтой бусад мэдээллээр хангах зорилготой юм.

#### **Хүчин төгөлдөр болох хугацаа**

38. Байгууллага нь энэхүү Стандартыг 2002 оны 7 дугаар сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2002 оны 7 дугаар сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.

- 38А. 2010 оны 01 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Сайжруулалтууд*-аар 17, 18, 22-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2011 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө.
- 38Б. 2011 оны 10 дугаар сард гаргасан *УСНББОУС 2011-ийн Сайжруулалтууд*-аар өмнө байсан 1-р параграфыг 1А параграф болгон шинээр дугаарлаж, шинэ 1-р параграфыг нэмж оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2013 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2013 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 38В. 2015 оны 01 дүгээр сард гаргасан *УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-ийн үр дүнд 39-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед *УСНББОУС 33*-ыг мөрдсөн бол уг нэмэлт өөрчлөлтийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.
- 38Г. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 2, 3-р параграфуудыг хассан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 38Д. 2017 оны 01 дүгээр сард гаргасан *УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл*-ийн үр дүнд 22-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн *УСНББОУС 40*-ийг мөрдөнө.
39. *УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д

## ХЭТ ИНФЛЯЦИТАЙ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЕИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

## Дүгнэлтийн Үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 10-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### **2008 онд гаргасан, НББОУС3-ийн СТОУС-ын Сайжруулалтууд-ын үр дүнд УСНББОУС 10-д хийсэн хянан засварлалт**

ДҮ1. УСНББОУС3 нь 2008 оны 5 дугаар сард НББОУС3-өөс гаргасан СТОУС-ын Сайжруулалтууд-д тусгасан, НББОУС 29-ийн хянан засварлалтыг нягталж шалгаад уг Стандартыг хянан засварлах болсон НББОУС3-ийн учир шалтгаантай ерөнхийдөө санал нийлсэн. УСНББОУС3 нь уг нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдөхгүй байх улсын секторын тусгай учир шалтгаан байхгүй гэж дүгнэсэн.

### **2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУС3-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 10-д хийсэн хянан засварлалт**

ДҮ2. УСНББОУС3 нь 2016 оны 4 дүгээр сард УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (а) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р параграфт* нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

## Үлгэрчилсэн жишээ

*Энэхүү жишээ нь УСНББОУС 10-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

ҮЖ1. Энэ Стандарт нь хэт инфляцитай эдийн засгийн үеийн валютаар тайлагнаж буй байгууллагуудын санхүүгийн тайланг, үүн дотроо нэгтгэсэн санхүүгийн тайланг дахин илэрхийлэх шаардлагуудыг тогтоодог.

ҮЖ2. Санхүүгийн тайланг дахин илэрхийлэх процессыг дараах жишээнд үлгэрчлэн харуулав. Энэхүү үлгэрчилсэн жишээг бэлтгэх үед:

- Тухайн тайлант үеийн цэвэр мөнгөн байдлын олз нь мөнгөн зүйлсийн бус хөрөнгө ба өр төлбөр, хуримтлагдсан ашиг, алдагдал болон санхүүгийн үр дүнгийн тайлангийн зүйлсийг дахин тайлагнасны үр дүн болох зөрүү байдлаар шууд бусаар үүссэн (28-р параграфыг үзнэ үү).
- Тухайн тайлант үеийн эцэст гар дээр байгаа бараа материалыг инфляцийн ерөнхий индекс 170 байх үед уг тайлант үеийн эцсээр худалдаж авсан гэж үзнэ.
- Үнийн ерөнхий индекс нь тухайн тайлант үеийн эхэнд 120, тайлант үеийн эцэст 180, тайлант үеийн туршид дундажаар 150 байсан.
- Орлого ба элэгдлээс бусад, зардлыг тухайн тайлант үеийн туршид жигд хуримтлуулна гэж үзнэ.
- Түүхэн өртөг нь 7,500ТН бүхий хөрөнгө бүрэн элэгдсэн бөгөөд данснаас хассан. Түүний үлдэх үнэ цэнэ нь тэг байсан.

## Хэт инфляцитай үеийн санхүүгийн тайлагнал

Жишээ

Санхүүгийн байдлын тайлан	Х0.01.01 (УСНББОУС 12-оор)	Х0.12.31 (Тохируулаагүй)	Индекс-жүүлэх хүчин зүйл	Х0.12.31 (УСНББОУС 12-оор)	Цэвэр мөнгөн байдлын олз/гарз
Мөнгө ба хөрөнгө оруулалт	5,000	10,000	-	10,000	-
Бараа материал	-	2,000	180/170	2,118	118
					<i>Дахин илэрхийлсэн</i>
<i>Биет хөрөнгө:</i>					
Түүхэн өртөг	47,500	40,000	180/120	60,000	20,000
Хуримтлагдсан элэгдэл	(22,500)	(20,000)	180/120	(30,000)	(10,000)
Дансны цэвэр үнэ	25,000	20,000	180/120	30,000	10,000
					<i>Дахин илэрхийлсэн</i>
<b>Нийт хөрөнгө</b>	<b>30,000</b>	<b>32,000</b>		<b>42,118</b>	
Зээл	26,000	26,000	-	26,000	
<b>Цэвэр хөрөнгө</b>					
Эхний үлдэгдэл	4,000	4,000	180/120	6,000	(2,000)
					<i>Дахин илэрхийлсэн</i>
Тайлант үеийн цэвэр ашиг (доор дурдсныг үз)		2,000	Доор дурдсныг үзнэ үү	10,118	1,100
	<b>4,000</b>	<b>6,000</b>		<b>16,118</b>	<b>9,218</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>					
Орлого		50,000	180/150	60,000	(10,000)
					<i>Дахин илэрхийлсэн</i>
Элэгдэл		(5,000)	180/120	(7,500)	(2,500)
					<i>Дахин илэрхийлсэн</i>
Бусад зардал		(43,000)	180/150	(51,600)	(8,600)
					<i>Дахин илэрхийлсэн</i>
Цэвэр мөнгөн байдлын олз				9,218	
Тухайн жилийн ашиг		2,000		10,118	(1,100)



## ХЭТ ИНФЛЯЦИТАЙ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЕИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

**Тайлбар:** Энэхүү Стандарт (27-р параграф) нь тухайн ажил гүйлгээг бүртгэсэн өдрөөс хойш индексэд орсон өөрчлөлтүүдийг ашигласнаар уг санхүүгийн үр дүнгийн тайлангийн зүйлсийг дахин илэрхийлэхийг шаарддаг. Энэхүү жишээнд элэгдлээс бусад, зардал болон орлогыг тухайн тайлант үеийн туршид жигд хуримтлуулсан бөгөөд инфляцийн дундаж хувь хэмжээг ашигласан. Санхүүгийн байдлын тайлан болон санхүүгийн үр дүнгийн тайлан дахь мөнгөн бус зүйлсэд үнийн ерөнхий индексийг ашигласнаар цэвэр мөнгөн байдлын олзыг (сүүлийн багана) шууд бусаар тооцоолсон (28-р параграф).

## НББОУС 29-ТЭЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 10, *Хэт Инфляцитай Эдийн Засгийн Үеийн Санхүүгийн Тайлагнал*-ыг НББОУС 29, *Хэт Инфляцитай Эдийн Засгийн Үеийн Санхүүгийн Тайлагнал*-аас үндсэндээ бэлтгэсэн бөгөөд 2008 оны 5 дугаар сард гаргасан, *СТОУС-ын Сайжруулалтууд*-ын нэг хэсэг байдлаар НББОУС 29-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг үүнд тусгасан болно. УСНББОУС 10 ба НББОУС 29-ийн хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- УСНББОУС 10 нь зарим тохиолдолд НББОУС 29-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь УСНББОУС 10 дахь “орлого” /revenue/, “санхүүгийн үр дүнгийн тайлан” ба “цэвэр хөрөнгө/өмч” гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. НББОУС 29 дэх адилтгах нэр томъёо нь “орлого” /income/, “орлогын тайлан” ба “өмч” юм.
- НББОУС 29 нь одоогийн өртгөөр тусгасан санхүүгийн тайланг дахин илэрхийлэх талаархи заавар удирдамжийг агуулсан байдаг. УСНББОУС 10-д ийм заавар удирдамжийг тусгаагүй болно.
- УСНББОУС 10 нь хэт инфляцитай эдийн засгийн үеийн валютаар тайлагнаж буй байгууллагын санхүүгийн тайланг шууд бус арга ашигласнаар дахин илэрхийлэх процессыг харуулсан үлгэрчилсэн жишээг агуулсан байдаг.

## УСНББОУС 11–БАРИЛГЫН ГЭРЭЭ

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) 11, *Барилгын Гэрээ* (1993 онд хянан засварласан)-нээс үндсэндээ бэлтгэсэн болно. НББОУС 11-ээс авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон ЕС4М 6ХН, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)

Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.

## УСНББОУС 11-БАРИЛГЫН ГЭРЭЭ

### УСНББОУС-ын түүх

Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

УСНББОУС 11, Барилгын Гэрээ-г 2001 оны 7 дугаар сард гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 11-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх (2015 оны 01 дүгээр сард гаргасан)

### УСНББОУС 11-ийн нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт

Өөрчлөгдсөн параграф	Хэрхэн өөрчилсөн	Юугаар өөрчилсөн
2	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
3	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
30	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
45	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
57А	Шинэ	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
57Б	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
58	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар

**УСНББОУС 11–БАРИЛГЫН ГЭРЭЭ**

**АГУУЛГА**

---

	Параграф
Зорилго	
Цар хүрээ	1-3
Тодорхойлолт	4-11
Барилгын гэрээ	5-10
Гэрээ гүйцэтгэгч	11
Барилгын гэрээг нэгтгэн нийлүүлэх ба хэсэгчлэн хуваах	12-15
Гэрээний орлого	16-22
Гэрээний өртөг зардал	23-29
Гэрээний орлого ба зардлын хүлээн зөвшөөрөлт	30-43
Хүлээгдэж буй алдагдлын хүлээн зөвшөөрөлт	44-48
Тооцооллын өөрчлөлт	49
Тодруулга	50-56
Хүчин төгөлдөр болох хугацаа	57-58
Дүгнэлтийн үндэслэл	
Хэрэгжүүлэх заавар удирдамж	
НББОУС 11-тэй харьцуулалт	

## БАРИЛГЫН ГЭРЭЭ

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 11, *Барилгын Гэрээ*-г 1-58-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 11-ийг түүний зорилгын агуулга, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

Энэ Стандартын зорилго нь барилгын гэрээтэй холбоотой өртөг зардал ба орлогын нягтлан бодох бүртгэлийн хандлагыг тодорхойлоход оршино. Энэ Стандарт нь:

- Барилгын гэрээ гэж ангилах хэлцлүүдийг тодорхойлно;
- Улсын секторт үүсэж болох барилгын гэрээний төрлүүдийн талаархи заавар удирдамжаар хангана; ба
- Гэрээний зардлын, хэрэв хамааралтай бол гэрээний орлогын хүлээн зөвшөөрөлт ба тодруулгын суурийг тусгайлан заана.

Барилгын гэрээгээр хийж гүйцэтгэх үйл ажиллагааны шинж төрлөөс хамааран тухайн гэрээт үйл ажиллагааг эхлэх өдөр ба дуусгах өдөр нь ихэвчлэн өөр өөр тайлант үеүүдэд хамаардаг.

Ихэнх улс орны хувьд, улсын секторын байгууллагуудын байгуулсан барилгын гэрээнд гэрээний орлогын дүнг тусгайлан заадаггүй. Харин барилгын үйл ажиллагааг эрхлэн явуулах мөнгө санг засгийн газрын нийтлэг орлогын төсвийн хуваарилалт буюу адилтгах хуваарилалт, эсвэл тусламж болон буцалтгүй тусламжийн сангаар бүрдүүлдэг. Ийм тохиолдолд барилгын гэрээний нягтлан бодох бүртгэлийн үндсэн асуудал нь (а) тухайн барилгын ажлыг гүйцэтгэсэн тайлант үед барилгын өртөг зардлыг хуваарилах, ба (б) холбогдох зардлыг хүлээн зөвшөөрөх явдал юм.

Зарим улс оронд, улсын секторын байгууллагуудын хийх барилгын гэрээг арилжааны сууриар, эсвэл арилжааны бус бөгөөд өртгийг бүрэн буюу хэсэгчлэн нөхөх байдлаар байгуулж болно. Ийм тохиолдолд барилгын гэрээний нягтлан бодох бүртгэлийн үндсэн асуудал нь тухайн барилгын ажлыг гүйцэтгэсэн тайлант үед гэрээний орлого ба гэрээний өртөг зардлын аль алиныг хуваарилах явдал байдаг.

## Цар хүрээ

1. **Нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар санхүүгийн тайлангаа бэлтгэн толилуулж буй гэрээ гүйцэтгэгч нь барилгын гэрээний нягтлан бодох бүртгэлд энэ Стандартыг мөрдөнө.**
2. [Хассан]
3. [Хассан]

## Тодорхойлолт

4. **Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:**

**Барилгын гэрээ** гэдэг нь тухайн нэг хөрөнгө эсвэл зураг төсөл, технологи, чиг үүрэг, эцсийн зорилго буюу ашиглалтын хувьд хоорондоо нягт уялдаатай, бие биенээсээ хамааралтай

хөрөнгүүдийн нэгдлийг барьж байгуулахын тулд тусгайлан тохиролцсон, гэрээ буюу адилтгах заавал биелүүлэх хэлцэл юм.

Гэрээ гүйцэтгэгч гэдэг нь барилгын гэрээний дагуу барилгын ажлыг гүйцэтгэдэг байгууллага юм.

Өртөг нэмэх буюу өртөгт суурилсан гэрээ гэдэг нь зөвшөөрөгдөх буюу өөр бусад байдлаар тодорхойлсон өртөг зардлыг, түүнчлэн арилжаанд суурилсан гэрээний хувьд эдгээр өртөг буюу тогтмол хөлсөн дээр хэрэв байгаа бол аливаа нэмэлт хувь хэмжээг уг гэрээ гүйцэтгэгчид нөхөн олгох барилгын гэрээ юм.

Тогтмол үнэтэй гэрээ гэдэг нь гэрээний тогтмол үнийг эсвэл гарцын нэгж тутамд тогтмол төлбөр төлөхийг тухайн гэрээ гүйцэтгэгч зөвшөөрсөн бөгөөд зарим тохиолдолд өртөг нэмэгдүүлэх заалт бүхий барилгын гэрээ юм.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д дахин нийтэлсэн болно.

#### Барилгын гэрээ

5. Гүүр, барилга, далан, дамжуулах хоолой, зам, усан онгоц, хонгил гэх мэт ганц хөрөнгийг барьж байгуулахын тулд барилгын гэрээг (энэ Стандартын үлдсэн хэсэгт барилгын гэрээ ба гэрээнүүд гэсэн нэр томъёог харилцан орлуулан хэрэглэсэн) байгуулж болно. Зураг төсөл, технологи, чиг үүрэг, эцсийн зорилго буюу ашиглалтын хувьд хоорондоо нягт уялдаатай, бие биенээсээ хамааралтай олон тооны хөрөнгүүдийг барьж байгуулахад мөн барилгын гэрээ байгуулж болно. Ийм гэрээний жишээнд усан хангамжийн сүлжээ систем, цэвэршүүлэх байгууламж болон дэд бүтцийн бусад цогц хөрөнгө хамаарна.
6. Энэ Стандартын зорилгын хувьд барилгын гэрээнд дараах зүйлс хамаарна:
  - (а) Тухайн хөрөнгийг барьж байгуулахтай шууд холбоотой үйлчилгээ үзүүлэх гэрээ. Жишээлбэл; төслийн менежерийн болон болон архитекторын үйлчилгээний гэрээ; ба
  - (б) Хөрөнгийг нураан буулгах эсвэл сэргээн засварлах, түүнчлэн хөрөнгийг нураан буулгасны дараа орчныг сэргээн засварлах гэрээ.
7. Энэ Стандартын зорилгын хувьд, барилгын гэрээ нь тухайн хэлцлийн талуудын зүгээс заавал биелүүлэх бүх хэлцлийг агуулах боловч баримтжуулсан гэрээ хэлбэртэй биш байж болно. Жишээлбэл; засгийн газрын хоёр алба нь хөрөнгийг барьж байгуулах албан ёсны хэлцэл хийж болох боловч тухайн улс оронд тэдгээр албадууд нь гэрээ байгуулах бүрэн эрх бүхий тусдаа хуулийн этгээдүүд биш учраас уг хэлцэл нь хууль ёсны гэрээг орлохгүй байж болох юм. Гэвч уг хэлцэл нь гэрээ



## БАРИЛГЫН ГЭРЭЭ

байгуулсантай адил эрх, үүргийг талуудад хүлээлгэдэг бол энэ Стандартын зорилгын хувьд барилгын гэрээ гэж үзнэ. Ийм заавал биелүүлэх хэлцэлд Сайдын өгсөн чиглэл, засгийн газрын шийдвэр, хууль тогтоогч байгууллагын шийдвэр (Улсын Их Хурлын тогтоол гэх мэт), харилцан ойлголцлын санамж бичиг хамаарч болно (гэхдээ зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй).

8. Барилгын гэрээг олон арга замаар томъёолж болох бөгөөд энэ Стандартын зорилгын хувьд тогтмол үнэтэй гэрээ, өртөг нэмэх буюу өртөгт суурилсан гэрээ гэж ангилна. Зарим арилжааны барилгын гэрээ нь тогтмол үнэтэй гэрээ ба өртөг нэмэх буюу өртөгт суурилсан гэрээний аль алины шинж чанарыг агуулсан байж болно. Жишээлбэл; тохиролцсон хамгийн өндөр үнэ бүхий өртөг нэмэх буюу өртөгт суурилсан гэрээ. Ийм тохиолдолд гэрээ гүйцэтгэгч нь гэрээний орлого ба зардлыг хэзээ хүлээн зөвшөөрөх эсэхийг тодорхойлохын тулд 31 ба 32-р параграфт заасан бүх нөхцлүүдийг харгалзан үзэх шаардлагатай байдаг.
9. Өртөг нэмэх буюу өртөгт суурилсан гэрээ нь арилжааны ба арилжааны бус гэрээний аль алиныг агуулдаг. Орлого нь тухайн гэрээ гүйцэтгэгчийн тохиролцсон барилгын өртөг зардлыг нөхөх ба тэрхүү гэрээний бусад талуудын олгох ашгийн хувь хэмжээг бүрдүүлэхүйц дүнтэй байна гэдгийг арилжааны гэрээнд тусгайлан заадаг. Гэвч улсын секторын байгууллага нь өөр байгууллагад зориулан хөрөнгийг барьж байгуулах ба үүнийхээ хариуд тухайн байгууллагаас эсвэл бусад талуудаас өртгийг бүрэн буюу хэсэгчлэн нөхөх төлбөр авах тийм арилжааны бус гэрээг бас байгуулж болно. Зарим тохиолдолд өртгийн нөхөлт нь уг хөрөнгө хүлээн авагч байгууллагын төлөх төлбөр болон бусад талуудаас авах, барилгын тусгай зорилго бүхий буцалтгүй тусламж буюу санхүүжилтээс бүрдэж болно.
10. Олон улс орны хувьд, улсын секторын нэг байгууллага нь улсын секторын өөр нэг байгууллагад зориулан хөрөнгийг барьж байгуулах тохиолдолд уг барилгын үйл ажиллагааны өртгийг тухайн хөрөнгө хүлээн авагчаас шууд нөхөн олгодоггүй. Харин барилгын үйл ажиллагааг (а) засгийн газрын ерөнхий зориулалттай сангаас тухайн гэрээ гүйцэтгэгчид олгох төсвийн нийтлэг хуваарилалт буюу бусад хуваарилалтаар, (б) гуравдагч тал болох санхүүжүүлэгч агентлагийн эсвэл бусад засгийн газрын ерөнхий зориулалттай буцалтгүй тусламжаар шууд бус хэлбэрээр санхүүжүүлдэг. Эдгээрийг энэ Стандартын зорилгын хувьд тогтмол үнэтэй гэрээ гэж ангилна.

### Гэрээ гүйцэтгэгч

11. Гэрээ гүйцэтгэгч нь өөр байгууллагын техникийн шаардлагад нийцүүлэн дэд бүтэц, барилга байгууламжийг барьж байгуулах, бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх эсвэл үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан байгууллага юм. “Гэрээ гүйцэтгэгч” нэр томъёонд ерөнхий буюу үндсэн гүйцэтгэгч, ерөнхий гэрээ гүйцэтгэгчийн туслан гүйцэтгэгч, барилгын менежер хамаарна.

## **Барилгын гэрээг нэгтгэн нийлүүлэх ба хэсэгчлэн хуваах**

12. Энэ Стандартын шаардлагуудыг барилгын гэрээ нэг бүрд ихэвчлэн тус тусад нь мөрддөг. Гэвч зарим тохиолдолд гэрээ буюу гэрээнүүдийн бүлгийн мөн чанарыг тусгахын тулд энэхүү Стандартыг нэг гэрээний тусдаа тодорхойлж болох бүрэлдэхүүн хэсгүүдэд эсвэл гэрээнүүдийн бүлэгт хамтад нь мөрдөх шаардлагатай болдог.
13. **Олон хөрөнгүүдийг хамрах гэрээний хувьд дараах тохиолдолд хөрөнгө нэг бүрийн барилгын ажлыг барилгын тусдаа гэрээ гэж үздэг:**
  - (a) Хөрөнгө нэг бүрээр саналыг тусдаа танилцуулсан;
  - (б) Хөрөнгө бүрийн хувьд тусдаа тохиролцох бөгөөд гэрээ гүйцэтгэгч болон захиалагч нь хөрөнгө нэг бүртэй холбоотой гэрээний тухайн хэсгийг хүлээн зөвшөөрөх эсвэл татгалзах боломжтой байх; ба
  - (в) Хөрөнгө тус бүрийн орлого ба өртөг зардлыг ялган тодорхойлох боломжтой байх.
14. **Нэг захиалагчтай эсвэл хэд хэдэн захиалагчидтай байгуулсан эсэхээс үл хамааран гэрээнүүдийн бүлгийг дараах тохиолдолд барилгын нэг гэрээ гэж үзнэ:**
  - (a) Гэрээнүүдийн бүлгийг нэг багц байдлаар хэлэлцэн тохиролцсон;
  - (б) Хэрэв ашигтай бол нэг нийтлэг ашигтай байх ганц төслийн бүрэлдэхүүн хэсэг болохуйцаар тухайн гэрээнүүд нь өөр хоорондоо нягт холбоотой байх;
  - (в) Гэрээнүүдийг нэгэн зэрэг эсвэл үргэлжилсэн дэс дарааллаар гүйцэтгэдэг байх.
15. **Захиалагчийн сонголтоор нэмэлт хөрөнгийг барьж байгуулахыг гэрээгээр зөвшөөрдөг эсвэл нэмэлт хөрөнгийг барьж байгуулна гэдгийг тусгахын тулд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох юм. Ийм нэмэлт хөрөнгө барьж байгуулах ажлыг дараах тохиолдолд барилгын тусдаа гэрээ гэж үзнэ:**
  - (a) Тухайн хөрөнгө нь анхны гэрээнд тусгагдсан хөрөнгө буюу хөрөнгүүдээс зураг төсөл, технологи, чиг үүргээрээ эрс ялгаатай байх; эсвэл
  - (б) Анхны гэрээний үнийг харгалзахгүйгээр тухайн хөрөнгийн үнийг хэлцэн тохирдог.

## Гэрээний орлого

16. **Гэрээний орлого нь дараах зүйлсээс бүрддэг:**
- (a) **Гэрээгээр тохиролцсон орлогын анхны дүн; ба**
  - (б) **Доорх тохиолдолд гэрээт ажил, хохирлын нэхэмжлэл, урамшуулалт төлбөрийн өөрчлөлтүүд:**
    - (i) **Тэдгээр нь орлого бий болгох нилээд их магадлалтай байх; ба**
    - (ii) **Тэдгээрийн дүнг найдвартай<sup>1</sup> хэмжих боломжтой байх.**
17. Хүлээн авсан буюу авах төлбөрийн бодит үнэ цэнээр гэрээний орлогыг хэмжинэ. Гэрээний орлогын анхны ба цаашдын хэмжилтийн аль алинд ирээдүйн үйл явдлын үр дүнгээс хамаарах янз бүрийн олон тодорхойгүй байдал нөлөө үзүүлдэг. Үйл явдал гарч тохиолдсон ба тодорхойгүй байдал шийдвэрлэгдсэн хэмжээгээр уг тооцооллыг байнга хянан засварлах шаардлагатай байдаг. Өртөг нэмэх буюу өртөгт суурилсан гэрээний хувьд орлогын анхны дүнг заагаагүй байж болох юм. Харин гэрээний хугацаанд хүлээгдэж буй өртөг зардлыг харгалзах гэх мэтээр тухайн гэрээний нөхцөл, болзлуудтай нийцсэн сууриар тооцоолох шаардлагатай байж болно.
18. Түүнчлэн, гэрээний орлогын дүн нь нэг тайлант үеэс нөгөө тайлант үед нэмэгдэх буюу буурч болно. Жишээлбэл:
- (a) Гэрээг анх тохиролцсон тайлант үеийн дараагийн тайлант үед тухайн гэрээний орлогыг нэмэгдүүлэх буюу бууруулах өөрчлөлт эсвэл хохирлын нэхэмжлэлийг гэрээ гүйцэтгэгч болон захиалагч нь зөвшөөрсөн байж болно;
  - (б) Тогтмол үнэ, өртөг нэмэх буюу өртөгт суурилсан гэрээгээр тохиролцсон орлогын дүн нь өртөг нэмэгдүүлэх болон бусад заалтын үр дүнд нэмэгдэж болох юм;
  - (в) Гэрээ гүйцэтгэгчээс хамааран тухайн гэрээний гүйцэтгэл хойшлогдсоноор тавигдсан торгуулийн улмаас гэрээний орлогын дүн буурч болно; эсвэл
  - (г) Гарцын нэгж тутамд тогтмол төлбөр бүхий тогтмол үнэтэй гэрээний хувьд тухайн гарцын тоо нэмэгдэх буюу буурсаны улмаас гэрээний орлого нэмэгдэж эсвэл буурч болно.
19. Өөрчлөлт нь тухайн гэрээний дагуу гүйцэтгэх ажлын цар хүрээнд өөрчлөлт оруулах талаархи захиалагчийн зааварчилгаа юм. Өөрчлөлт нь

---

<sup>1</sup> Найдвартай мэдээлэл нь материаллаг алдаа ба туйлшралаас ангид байх бөгөөд өөрийн илэрхийлэхээр зориулагдсан буюу илэрхийлнэ гэж ул үндэслэлтэйгээр хүлээж болох зүйлсийг үнэн зөв илэрхийлэхдээ хэрэглэгчдээс хамаардаг байж болох юм. Найдвартай байдлын тайлбарын талаархи шилжилтийн арга хандлагыг УСНББОУС 1-ийн ДҮ16-р параграфт авч хэлэлцсэн.

гэрээний орлогыг нэмэгдүүлэх эсвэл бууруулахад хүргэж болно. Өөрчлөлтийн жишээнд тухайн хөрөнгийн техникийн шаардлага буюу зураг төслийн өөрчлөлт, гэрээний үргэлжлэх хугацааны өөрчлөлт хамаарна. Дараах тохиолдолд өөрчлөлтийг гэрээний орлогод оруулж тооцно:

(а) Захиалагч нь тухайн өөрчлөлт болон түүнээс үр дүнд нэмэгдэх орлогын дүнг зөвшөөрөх нилээд их магадлалтай байх; ба

(б) Орлогын дүнг найдвартай хэмжиж чадах.

20. Хохирлын нэхэмжлэл гэдэг нь тухайн гэрээний үнэд ороогүй өртөг зардлын хувьд захиалагч буюу бусад талаас нөхөн төлбөр байдлаар уг гэрээ гүйцэтгэгчийн авахаар эрмэлзэж буй дүн юм. Хохирлын нэхэмжлэл нь тухайлбал, захиалагчаас хамаарсан хойшлолт, техникийн шаардлага буюу зураг төслийн алдаа, гэрээт ажлын маргаантай өөрчлөлт зэргээс үүсэж болно. Хохирлын нэхэмжлэлээс үүсэх орлогын дүнгийн хэмжилт нь ихээхэн тодорхойгүй бөгөөд хэлцэл тохиролцооны үр дүнгээс ямагт хамаардаг. Иймээс зөвхөн дараах тохиолдолд хохирлын нэхэмжлэлийг гэрээний орлогод оруулж тооцно:

(а) Захиалагч нь хохирлын нэхэмжлэлийг зөвшөөрөх нилээд магадлалтай гэх мэтээр тохиролцоо нь нилээд ахицтай түвшинд хүрсэн; ба

(б) Захиалагчийн зөвшөөрөх магадлалтай дүнг найдвартай хэмжиж чадах.

21. Урамшуулалт төлбөр нь тогтоосон гүйцэтгэлийн стандартыг хангасан буюу давуулж биелүүлсэн тохиолдолд гэрээ гүйцэтгэгчид төлдөг нэмэлт дүн юм. Жишээлбэл; гэрээт ажлыг хугацаанаас өмнө дуусгавал тухайн гэрээ гүйцэтгэгчид урамшуулалт төлбөр олгохыг гэрээгээр зөвшөөрсөн байж болно. Дараах тохиолдолд урамшуулалт төлбөрийг гэрээний орлогод оруулж тооцно:

(а) Тогтоосон гүйцэтгэлийн стандарт хангагдах буюу түүнийг давуулж биелүүлэх нилээд их магадлалтай байдлаар уг гэрээнд хангалттай ахиц дэвшил гарсан; ба

(б) Урамшуулалт төлбөрийн дүнг найдвартай хэмжиж чадах.

22. Гуравдагч талын санхүүжилтийн агентлагаас туслан гүйцэтгэгчдэд шууд төлсөн, тухайн барилгын гэрээтэй холбоотой дүнгүүд нь уг гэрээний нөхцлүүдийн дагуу гүйцэтгэгчийн орлогын тодорхойлолт ба хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангах эсэхийг тодорхойлохын тулд гэрээ гүйцэтгэгч нь эдгээр бүх дүнгүүдийг хянан үнэлэх хэрэгтэй. Орлогын тодорхойлолт ба хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангах дүнгүүдийг тухайн гэрээ гүйцэтгэгч нь гэрээний бусад орлоготой ижил арга замаар тайлагнавал зохино. Ийм дүнгүүдийг мөн гэрээний өртөг зардал гэж хүлээн зөвшөөрөх хэрэгтэй (25-р параграфыг үзнэ үү). Санхүүжилтийн агентлагууд нь үндэсний болон олон улсын тусламжийн агентлагууд, олон улсын ба хоёр улсын хөгжлийн банкууд байж болно.

## Гэрээний өртөг зардал

23. Гэрээний өртөг зардал нь дараах зүйлсээс бүрддэг:

- (a) Тухайн гэрээнд шууд хамаарах өртөг зардал;
- (б) Гэрээний үйл ажиллагаанд ерөнхийдөө хамаарах, түүнчлэн системтэй ба оновчтой сууриар тухайн гэрээнд хуваарилж болох өртөг зардал; ба
- (в) Гэрээний нөхцлүүдийн дагуу уг захиалагчаас тусгайлан нэхэмжилж болох бусад зардал.

24. Тухайн гэрээнд шууд хамаарах өртөг зардалд дараах зүйлс хамаарна:

- (a) Барилгын ажлын талбай дахь хөдөлмөрийн зардал үүн дотроо, талбайн хяналт;
- (б) Барилгын ажилд ашигласан материалын зардал;
- (в) Гэрээт ажилд ашигласан үндсэн хөрөнгийн элэгдэл;
- (г) Гэрээт ажлын талбар руу болон талбараас барилга, тоног төхөөрөмж, материалыг зөөж тээвэрлэх зардал;
- (д) Барилга, тоног төхөөрөмжийг хөлсөөр ашигласны зардал;
- (е) Тухайн гэрээтэй шууд холбоотой зураг төсөл болон техник туслалцааны зардал;
- (ж) Сэргээн засварлалт болон баталгаат ажлын тооцоолсон зардал, үүн дотроо хүлээгдэж буй баталгаат засварын зардал; ба
- (и) Гуравдагч талын хохирлын нэхэмжлэл.

Гэрээний орлогод тооцож оруулаагүй аливаа тохиолдлын шинжтэй орлого, жишээлбэл, илүү гарсан материалыг тухайн гэрээний эцэст борлуулснаас олсон орлогоор эдгээр өртөг зардлыг бууруулж болох юм.

25. Туслан гүйцэтгэгчээс шууд төлсөн бөгөөд гуравдагч талын санхүүжилтийн агентлагаас нөхөн олгох тухайн барилгын гэрээтэй холбоотой дүнгүүд нь гэрээний өртөг зардлын шалгуурыг хангах эсэхийг тодорхойлохын тулд гэрээ гүйцэтгэгч нь эдгээр бүх дүнгүүдийг хянан үнэлэх хэрэгтэй. Гэрээний зардлын тодорхойлолт ба хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангах дүнгүүдийг тухайн гэрээ гүйцэтгэгч нь гэрээний бусад зардалтай ижил арга замаар тайлагнавал зохино. Орлогын тодорхойлолт ба хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангах бөгөөд гуравдагч талын санхүүжилтийн агентлагаас нөхөн олгох дүнгүүдийг тухайн гэрээ гүйцэтгэгч нь гэрээний бусад орлоготой ижил арга замаар тайлагнавал зохино (22-р параграфыг үзнэ үү).

26. Гэрээний үйл ажиллагаанд ерөнхийдөө хамаарах бөгөөд тухайн гэрээнд хуваарилж болох өртөг зардалд дараах зүйлс хамаарна:

## БАРИЛГЫН ГЭРЭЭ

- (а) Даатгал;
- (б) Тухайн гэрээтэй шууд холбоогүй зураг төслийн зардал; ба
- (в) Барилгын ажлын нэмэгдэл зардал.

Эдгээр өртөг зардлыг (а) системтэй ба оновчтой аргыг ашиглан, (б) ижил төсөөтэй шинж чанар бүхий бүх зардалд тууштай мөрдсөнөөр хуваарилна. Уг хуваарилалт нь барилгын үйл ажиллагааны хэвийн түвшинд үндэслэнэ. Барилгын ажлын нэмэгдэл зардалд барилгын ажилчдын цалин хөлсийг тооцоолох, боловсруулах гэх мэт зардал хамаарна. Гэрээ гүйцэтгэгч нь УСНББОУС 5, *Зээлийн өртөг*-т заасан зөвшөөрөгдсөн сонголтот хандлагыг мөрддөг тохиолдолд гэрээний үйл ажиллагаанд ерөнхийдөө хамаарах бөгөөд тухайн гэрээнд хуваарилж болох өртөг зардалд зээлийн өртөг хамаарна.

27. Гэрээний нөхцлүүдийн дагуу захиалагчаас тусгайлан нэхэмжилж болох өртөг зардал нь нөхөн олгохоор тухайн гэрээнд тусгайлан заасан, зарим ерөнхий удирдлагын зардал ба хөгжүүлэлтийн зардлыг багтаасан байж болно.
28. Гэрээний үйл ажиллагаанд хамааруулах буюу гэрээнд хуваарилах боломжгүй зардлыг тухайн барилгын гэрээний өртөг зардалд оруулахгүй. Ийм зардалд дараах зүйлс хамаарна:
- (а) Нөхөн олгохоор гэрээнд тусгайлан заагаагүй ерөнхий удирдлагын зардал;
  - (б) Борлуулалтын зардал;
  - (в) Нөхөн олгохоор гэрээнд тусгайлан заагаагүй судалгаа ба хөгжүүлэлтийн зардал;
  - (г) Тухайн гэрээнд ашиглагдаагүй, сул зогссон үндсэн хөрөнгийн элэгдэл.
29. Гэрээний өртөг зардал нь гэрээг байгуулж баталгаажуулсан өдрөөс түүнийг эцэслэн дуусгах хүртэлх хугацаанд тухайн гэрээнд хамааруулж болох өртөг зардлыг агуулсан байна. Гэвч гэрээтэй шууд холбоотой бөгөөд түүнийг байгуулж баталгаажуулахад гарсан өртөг зардлыг тусад нь тодорхойлж, дүнг найдвартай хэмжиж чадах ба уг гэрээг олж авна гэдэг нь нилээд их магадлалтай тохиолдолд тэрхүү зардлыг тухайн гэрээний өртөг зардлын нэг хэсэг гэж үзнэ. Гэрээг дараагийн тайлант үед олж авсан бол тухайн гэрээг байгуулж баталгаажуулахад гарсан зардлыг уг гэрээний өртөг зардалд оруулахгүй, харин гарсан тайлант үед нь зардал гэж хүлээн зөвшөөрнө.

### **Гэрээний орлого ба зардлын хүлээн зөвшөөрөлт**

30. Барилгын гэрээний үр дүнг найдвартай тооцоолж чадах тохиолдолд уг барилгын гэрээтэй холбоотой гэрээний орлого болон гэрээний зардлыг тухайн тайлант үеийн эцэс дэх гэрээний үйл ажиллагааны

иж бүрдлийн үе шатыг харгалзсанаар орлого ба зардал гэж тус тус хүлээн зөвшөөрнө. 44-р параграфыг мөрдөх тухайн барилгын гэрээний хүлээгдэж буй алдагдлыг 44-р параграфын дагуу зардал гэж нэн даруй хүлээн зөвшөөрнө.

31. Тогтмол үнэтэй гэрээний хувьд, дараах бүх нөхцөл хангагдсан тохиолдолд барилгын гэрээний үр дүнг найдвартай тооцоолж болно:
- (a) Хэрэв байгаа бол гэрээний нийт орлогыг найдвартай хэмжиж чадах;
  - (б) Гэрээтэй холбоотой эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь тухайн байгууллагад орох нилээд их магадлалтай байх;
  - (в) Тухайн тайлант үеийн эцсийн байдлаар уг гэрээг дуусгах гэрээний өртөг зардал ба гэрээний иж бүрдлийн үе шатыг найдвартай хэмжиж чадах; ба
  - (г) Гэрээний бодитой гарсан өртөг зардлыг өмнөх тооцоололтой харьцуулах боломжтой болохын тулд тухайн гэрээнд хамааруулж болох гэрээний өртөг зардлыг илт ойлгомжтой ялган тодорхойлох ба найдвартай хэмжиж чадах.
32. Өртөг нэмэх буюу өртөгт суурилсан гэрээний хувьд, дараах бүх нөхцөл хангагдсан тохиолдолд барилгын гэрээний үр дүнг найдвартай тооцоолж болно:
- (a) Гэрээтэй холбоотой эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь тухайн байгууллагад орох нилээд их магадлалтай байх;
  - (б) Тусгайлан нөхөн олгогдох эсэхээс үл хамааран тухайн гэрээнд хамааруулж болох гэрээний өртөг зардлыг илт ойлгомжтой ялган тодорхойлох ба найдвартай хэмжиж чадах.
33. Гэрээний иж бүрдлийн үе шатыг харгалзан лавлагаа болгосноор орлого, зардлыг хүлээн зөвшөөрөхийг ихэвчлэн гүйцэтгэлийн хувийн жингийн арга гэж нэрлэдэг. Энэхүү аргын дагуу, тухайн иж бүрдлийн үе шатанд хүрэхийн тулд гаргасан гэрээний өртөг зардалтай гэрээний орлогыг уялдуулдаг бөгөөд хийж дуусгасан ажилтай хувь тэнцүүлэн хуваарилах боломжтой байдлаар орлого, зардал, ашиг/алдагдлыг тайлагнах үр дүнтэй байдаг. Энэ арга нь тухайн тайлант үеийн турш дахь гэрээний үйл ажиллагаа болон гүйцэтгэлийн хэмжээний талаархи ач холбогдолтой мэдээллээр хангадаг.
34. Гүйцэтгэлийн хувийн жингийн аргын дагуу, гэрээний орлогыг тухайн гэрээт ажлыг гүйцэтгэсэн тайлант үеүдийн санхүүгийн үр дүнгийн тайланд орлого гэж хүлээн зөвшөөрнө. Гэрээний өртөг зардлыг ихэвчлэн тухайн ажлыг гүйцэтгэсэн тайлант үеүдийн санхүүгийн үр дүнгийн тайланд зардал гэж хүлээн зөвшөөрнө. Харин гэрээний өртөг зардлыг тухайн барилгын гэрээний талуудаас бүрэн нөхөхөөр уг гэрээний эхэнд төлөвлөсөн

## БАРИЛГЫН ГЭРЭЭ

тохиолдолд гэрээний нийт орлогоос гэрээний нийт өртөг зардлын давахаар хүлээгдэж буй аливаа хэтэрсэн дүнг 44-р параграфын дагуу зардал гэж нэн даруй хүлээн зөвшөөрнө.

35. Гэрээ гүйцэтгэгч нь тухайн гэрээний ирээдүйн үйл ажиллагаатай холбоотой гэрээний өртөг зардлыг гаргасан байж болно. Ийм өртөг зардал нь нөхөн олгогдох нилээд их магадлалтай тохиолдолд тэдгээрийг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө. Ийм өртөг зардал нь захиалагчаас авах дүнг илэрхийлэх бөгөөд дуусаагүй гэрээт ажил гэж ихэвчлэн ангилдаг.
36. Гэрээтэй холбоотой эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь тухайн байгууллагад орох нилээд их магадлалтай зөвхөн тийм тохиолдолд барилгын гэрээний үр дүнг найдвартай тооцоолж чадна. Харин орлогод нэгэнт тусгасан ба санхүүгийн үр дүнгийн тайланд аль хэлийн хүлээн зөвшөөрсөн дүнгийн цуглуулалтын хувьд тодорхойгүй байдал үүссэн тохиолдолд уг үл цуглуулагдах дүн буюу нөхөн төлөгдөх магадлалгүй болсон дүнг тэрхүү гэрээний орлогын тохируулга байдлаар биш, харин зардал гэж хүлээн зөвшөөрнө.
37. Байгууллага нь тухайн гэрээний хувьд бусад талуудтай дараах зүйлсийг тохиролцсоны дараа ерөнхийдөө найдвартай тооцоолол хийх боломжтой болдог:
- (а) Барьж байгуулах хөрөнгийн талаархи тал тус бүрийн хууль ёсны эрх;
  - (б) Хэрэв байгаа бол арилжин солилцох төлбөр; ба
  - (в) Төлбөрийг барагдуулах арга хэлбэр ба нөхцөл.

Санхүүгийн төсөвлөлтийн болон тайлагналын үр дүнтэй дотоод системтэй байх нь байгууллагын хувьд мөн ихэвчлэн зайлшгүй шаардлагатай байдаг. Гэрээг гүйцэтгэж, ахиц өрнөл гарахын хирээр байгууллага нь гэрээний орлого ба гэрээний өртөг зардлын тооцооллыг нягталж шалгах ба шаардлагатай бол засварлан өөрчилдөг. Ийм засвар өөрчлөлт хийх шаардлагатай байдал нь тухайн гэрээний үр дүнг найдвартай тооцоолж чадахгүй гэдгийг заавал илэрхийлэх албагүй юм.

38. Гэрээний иж бүрдлийн үе шатыг янз бүрийн аргаар тодорхойлж болох юм. Байгууллага нь гүйцэтгэсэн ажлыг найдвартай хэмжих аргыг ашиглана. Гэрээний шинж төрлөөс хамааран дараах аргуудыг ашиглаж болох юм:
- (а) Гэрээний тооцоолсон нийт өртөгтэй харьцуулахад тухайн өдөр хүртэл гүйцэтгэсэн ажлын хувьд гарсан гэрээний өртөг зардлын хувийн жин;
  - (б) Гүйцэтгэсэн ажлын судалгаа; эсвэл
  - (в) Гэрээт ажлын биет гүйцэтгэлийн хувь хэмжээ.

Захиалагчаас хүлээн авсан явцын төлбөр ба урьдчилгаа нь гүйцэтгэсэн ажлыг ямагт илэрхийлээд байдаггүй.



39. Тухайн өдөр хүртэл гарсан гэрээний өртөг зардлыг харгалзсанаар иж бүрдлийн үе шатыг тодорхойлдог тохиолдолд гүйцэтгэсэн ажлыг зөвхөн тусган илэрхийлэх гэрээний өртөг зардлыг тэрхүү өдөр хүртэл гарсан өртөг зардалд оруулна. Ийм өртөг зардалд хамаарахгүй гэрээний өртөг зардлын жишээ нь:
- (а) Гэрээний дагуу ирээдүйд хийгдэх үйл ажиллагаатай холбоотой гэрээний өртөг зардал. Тухайлбал; материалыг уг гэрээнд тусгайлан зориулж бэлтгэснээс бусад тохиолдолд гэрээт ажлын талбайд хүргэсэн буюу гэрээнд ашиглахын тулд нөөцөлсөн боловч харахан суурилуулаагүй, гэрээ гүйцэтгэлийн явцад ашиглаагүй буюу зарцуулаагүй материалын зардал; ба
  - (б) Туслан гүйцэтгэх гэрээний дагуу гүйцэтгэх ажлын урьдчилгаа болгон туслан гүйцэтгэгчид олгосон төлбөр.
40. **Барилгын гэрээний үр дүнг найдвартай тооцоолж чадахгүй тохиолдолд:**
- (а) **Нөхөн олгогдох нилээд их магадлалтай, гэрээний зөвхөн гарсан өртөг зардлын хэмжээгээр орлогыг хүлээн зөвшөөрнө; ба**
  - (б) **Гэрээний өртөг зардлыг тэдгээрийн гарсан тайлант үед зардал гэж хүлээн зөвшөөрнө.**

**44-р параграфыг мөрдөх тухайн барилгын гэрээний хүлээгдэж буй алдагдлыг 44-р параграфын дагуу зардал гэж нэн даруй хүлээн зөвшөөрнө.**

41. Гэрээний эхний үе шатуудын явцад тухайн гэрээний үр дүнг ихэвчлэн найдвартай тооцоолж чаддаггүй. Гэвч байгууллага нь тухайн гарсан гэрээний өртөг зардлыг нөхөх нилээд их магадлалтай байж болно. Иймээс нөхөн төлөгдөхөөр хүлээгдэж буй зөвхөн гарсан өртөг зардлын хэмжээгээр гэрээний орлогыг хүлээн зөвшөөрдөг. Гэрээний үр дүнг найдвартай тооцоолж чадахгүй учраас ашиг, алдагдал хүлээн зөвшөөрөхгүй. Хэдийгээр гэрээний үр дүнг найдвартай тооцоолж чадахгүй боловч гэрээний нийт өртөг зардал нь гэрээний нийт орлогоос давж илүү гарах нилээд их магадлалтай байж болох юм. Ийм тохиолдолд тухайн гэрээний нийт орлогоос давж илүү гарах гэрээний нийт өртөг зардлын аливаа хүлээгдэж буй хэтрэлтийг 44-р параграфын дагуу зардал гэж нэн даруй хүлээн зөвшөөрнө.
42. Гэрээний талуудаас нөхөн олгогдох ёстой уг гэрээний өртөг зардал нь нөхөн төлөгдөх магадлал багатай болсон тохиолдолд тэдгээрийг зардал гэж нэн даруй хүлээн зөвшөөрнө. Гэрээний гарсан өртөг зардал нөхөгдөх магадлал багатай, ингэснээр уг гэрээний өртөг зардлыг нэн даруй зардал гэж хүлээн зөвшөөрөх шаардлагатай байж болох нөхцөл байдлын жишээнд дараах гэрээ хамаарна:

## БАРИЛГЫН ГЭРЭЭ

- (а) Энэ нь бүрэн хууль ёсны бус, өөрөөр хэлбэл тэдгээрийн хүчин төгөлдөр байдал нь ноцтой эргэлзээтэй болсон;
- (б) Гэрээний хэрэгжилт нь зарга маргаан буюу хууль тогтоомжийн үр дүнгээс хамааралтай байх;
- (в) Энэ нь битүүмжлэх буюу улсын орлого болгон хураах магадлалтай үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой;
- (г) Захиалагч нь өөрийн үүргийг биелүүлж чадахгүй болсон; эсвэл
- (д) Гэрээ гүйцэтгэгч нь гэрээгээ дуусгаж чадахааргүй буюу өөр бусад байдлаар тухайн гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон.

43. **Гэрээний үр дүнг найдвартай тооцоолоход саад учруулж буй тодорхойгүй байдал арилсан тохиолдолд тухайн барилгын гэрээтэй холбоотой орлого ба зардлыг 40-р параграфын дагуу биш, харин 30-р параграфын дагуу хүлээн зөвшөөрнө.**

### **Хүлээгдэж буй алдагдлын хүлээн зөвшөөрөлт**

44. **Гэрээний өртөг зардлыг тухайн барилгын гэрээний талуудаас бүрэн нөхөхөөр уг гэрээний эхэнд төлөвлөсөн барилгын гэрээний хувьд гэрээний нийт орлогоос гэрээний нийт өртөг зардал нь давах нилээд их магадлалтай тохиолдолд хүлээгдэж буй алдагдлыг зардал гэж нэн даруй хүлээн зөвшөөрнө.**

45. Улсын секторын байгууллагууд нь барилгын өртөг зардлыг нөхөхөд чиглэгдсэн орлогыг тухайн гэрээний бусад талуудаас олгоно гэдгийг тусгайлан заасан барилгын гэрээг байгуулж болох юм. Ийм байдал нь тухайлбал, дараах тохиолдолд үүсэж болно:

- (а) Үйл ажиллагаагаа санхүүжүүлэхийн тулд засгийн газрын төсвийн хуваарилалт буюу адилтгах хуваарилалтаас ихээхэн хамааралтай байдаг засгийн газрын алба болон агентлагууд нь арилжааны буюу өртөг бүрэн нөхөх сууриар хөрөнгөө барьж байгуулахын тулд улсын секторын худалдаа арилжааны байгууллага эсвэл хувийн хэвшлийн байгууллагатай мөн гэрээ байгуулах бүрэн эрхтэй байх; эсвэл
- (б) Засгийн газрын алба, агентлагууд нь “захиалагч-нийлүүлэгч” болон засгийн газрын үүнтэй адилтгах загварын дагуу хийгдэж болох холбоогүй талуудын буюу арилжааны сууриар өөр хоорондоо ажил гүйлгээ хийдэг байх.

Ийм тохиолдолд барилгын гэрээгээр хүлээгдэж буй алдагдлыг 44-р параграфын дагуу нэн даруй хүлээн зөвшөөрнө.

46. 9-р параграфт заасанчлан, зарим тохиолдолд улсын секторын байгууллага нь бүрэн өртгөөс бага нөхөн төлбөрийг тухайн гэрээний бусад талуудаас авах барилгын гэрээг байгуулж болох юм. Ийм тохиолдолд тухайн барилгын гэрээнд тусгайлан заасан дүнгээс давсан

санхүүжилтийг засгийн газрын сангийн төсвийн хуваарилалт буюу бусад хуваарилалтаас эсвэл гуравдагч талын санхүүжүүлэгч агентлаг буюу бусад засгийн газрын ерөнхий зориулалттай буцалтгүй тусламжаас уг гэрээ гүйцэтгэгчид олгоно. 44-р параграфын шаардлагуудыг ийм барилгын гэрээнд мөрдөхгүй.

47. Аливаа алдагдлын дүнг 44-р параграфын дагуу тодорхойлох үед, гэрээний нийт орлого ба нийт өртөг зардал нь 22 ба 25-р параграфт заасанчлан, гуравдагч талын санхүүжүүлэгч агентлагаас тухайн туслан гүйцэтгэгчдэд шууд төлсөн төлбөрүүдийг агуулсан байж болно.
48. Ийм алдагдлын дүнг дараах зүйлсээс хамааралгүйгээр тодорхойлно:
- (a) Тухайн гэрээний дагуу ажил эхэлсэн, үгүй эсэх;
  - (б) Гэрээний үйл ажиллагааны иж бүрдлийн үе шат; эсвэл
  - (в) 14-р параграфын дагуу барилгын нэг гэрээ гэж үзэхгүй, арилжааны бусад барилгын гэрээнээс үүсэхээр хүлээгдэж буй ашгийн дүн.

### **Тооцооллын өөрчлөлт**

49. Гүйцэтгэлийн хувийн жингийн аргыг тухайн гэрээний орлого ба гэрээний өртөг зардлын одоогийн тооцоололд тайлангийн үе нэг бүрд хуримтлагдсан сууриар хэрэглэнэ. Иймээс гэрээний орлого ба гэрээний өртөг зардлын тооцооллын өөрчлөлтийн үр нөлөө эсвэл гэрээний үр дүнгийн тооцооллын өөрчлөлтийн үр нөлөөг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж тайлагнана (УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-г үзнэ үү). Өөрчлөлт хийсэн тайлант үед болон дараагийн тайлант үеүдийн санхүүгийн үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрсөн орлого ба зардлын дүнг тодорхойлохдоо тухайн өөрчилсөн тооцооллыг ашиглана.

### **Тодруулга**

50. **Байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:**
- (a) **Тайлант үед орлогоор хүлээн зөвшөөрсөн гэрээний орлогын дүн;**
  - (б) **Тайлант үед хүлээн зөвшөөрсөн гэрээний орлогыг тодорхойлоход ашигласан арга; ба**
  - (в) **Дуусаагүй байгаа гэрээний иж бүрдлийн үе шатыг тодорхойлоход ашигласан арга.**
51. **Байгууллага нь тайлант үеийн эцэст дуусаагүй байгаа гэрээ тус бүрийн хувьд дараах зүйлсийг тодруулна:**
- (a) **Тухайн өдөр хүртэл гарсан зардал ба хүлээн зөвшөөрсөн ашгийн (хүлээн зөвшөөрсөн алдагдлыг хасна) нийт дүн;**

(б) **Хүлээн авсан урьдчилгааны дүн; ба**

(в) **Үлдээх мөнгөний дүн.**

52. Үлдээх мөнгө нь тухайн дүнгийн төлөлтийн хувьд гэрээнд тусгайлан заасан нөхцлүүд хангагдах буюу доголдлыг засварлах хүртэл төлөгдөхгүй, явцын нэхэмжлэлийн дүн юм. Явцын нэхэмжлэл нь тухайн дүнг захиалагч төлсөн эсэхээс үл хамааран уг гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын хувьд нэхэмжилсэн гэрээний орлогын дүн юм. Урьдчилгаа нь холбогдох ажлыг гүйцэтгэхээс өмнө уг гэрээ гүйцэтгэгчийн хүлээн авсан гэрээний орлогын дүн юм.

53. **Байгууллага нь дараах зүйлсийг толилуулна:**

(а) **Гэрээт ажлын хувьд захиалагчаас авах нийт дүнг хөрөнгө гэж;**

(б) **Гэрээт ажлын хувьд захиалагчид төлөх нийт дүнг өр төлбөр гэж.**

54. Гэрээт ажлын хувьд захиалагчаас авах нийт дүн нь дараах зүйлсийн цэвэр дүн байна:

(а) Гарсан өртөг зардал дээр хүлээн зөвшөөрсөн ашгийг нэмсэн дүн; үүнээс хасах нь:

(б) Гарсан өртөг зардал дээр хүлээн зөвшөөрсөн ашгийг нэмсэн дүн нь явцын нэхэмжлэлээс илүү гарсан гэрээний орлогоор (хүлээн зөвшөөрсөн алдагдлыг хасах) нөхөгдөх, хараахан дуусаагүй байгаа бүх гэрээний хувьд хүлээн зөвшөөрсөн алдагдал ба явцын нэхэмжлэлийн нийлбэр дүн.

55. Гэрээт ажлын хувьд захиалагчид төлөх нийт дүн нь дараах зүйлсийн цэвэр дүн байна:

(а) Гарсан өртөг зардал дээр хүлээн зөвшөөрсөн ашгийг нэмсэн дүн; үүнээс хасах нь:

(б) Гэрээний орлогоор (хүлээн зөвшөөрсөн алдагдлыг хасах) нөхөгдөх, гарсан өртөг зардал дээр хүлээн зөвшөөрсөн ашгийг нэмсэн дүнгээс тухайн явцын нэхэмжлэл нь давж илүү гарсан, хараахан дуусаагүй байгаа бүх гэрээний хувьд хүлээн зөвшөөрсөн алдагдал ба явцын нэхэмжлэлийн нийлбэр дүн.

56. Болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгийн толилуулгын талаархи заавар удирдамжийг УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-өөс үзэж болно. Болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө нь баталгаат зардал, хохирлын нэхэмжлэл, торгууль, боломжит гарз гэх мэт зүйлсээс үүсэж болно.

## **Хүчин төгөлдөр болох хугацаа**

57. **Байгууллага нь энэхүү Стандартыг 2002 оны 7 дугаар сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн**

санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2002 оны 7 дугаар сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.

- 57А. 2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-ийн үр дүнд 58-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед УСНББОУС 33-ыг мөрдсөн бол уг нэмэлт өөрчлөлтийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.
- 57Б. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 2, 3-р параграфуудыг хасаж, 45-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
58. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

## Дүгнэлтийн Үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 11-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

**2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУС3-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 11-д хийсэн хянан засварлалт**

ДҮ1. УСНББОУС3 нь 2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (а) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р* параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

## Хэрэгжүүлэх заавар удирдамж

*Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 11-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### Нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулга

ХЗУ1. Гэрээний бусад талуудаас өртгийг бүрэн буюу хэсэгчлэн нөхөх, эсвэл өртгийг нөхөхгүй төлбөр авах арилжааны бус барилгын гэрээг засгийн газрын бусад агентлагтай байгуулдаг тийм байгууллагын хувьд хийгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулгын жишээг доор харуулав. Мөн уг байгууллага нь улсын секторын худалдаа арилжааны байгууллагууд болон хувийн хэвшлийн байгууллагуудтай арилжааны барилгын гэрээ хийх, түүнчлэн улсын зарим эмнэлэг, их дээд сургуультай өртгийг бүрэн нөхөх барилгын гэрээ байгуулах бүрэн эрхтэй байдаг.

#### *Арилжааны бус гэрээ*

ХЗУ2. Гэрээ тус бүрийн хувьд тухайн өдөр хүртэл зарцуулсан хөдөлмөр цагийг тооцоолсон нийт хөдөлмөр цагт харьцуулсан хувийн жинг лавлагаа болгосноор хэмждэг гүйцэтгэлийн хувийн жингийн аргын дагуу уг гэрээний өртөг зардлыг зардал гэж хүлээн зөвшөөрнө. Зарим тохиолдолд, барилгын тодорхой үйл ажиллагаа болон техникийн хяналтыг “гэрээ гүйцэтгэлийн” тогтмол хөлстэйгээр хувийн хэвшлийн гэрээ гүйцэтгэгч нараар гүйцэтгүүлэхээр туслан гүйцэтгэх гэрээг байгуулдаг. Ийм тохиолдолд туслан гүйцэтгэх гэрээний өртөг зардлыг уг туслан гүйцэтгэх гэрээ нэг бүрээр гүйцэтгэлийн хувийн жингийн аргаар зардал гэж хүлээн зөвшөөрнө.

ХЗУ3. Уг байгууллагын байгуулсан өртөг бүрэн нөхөлтийн болон өртөг хэсэгчлэн нөхөлтийн гэрээнүүдээс үүсэх гэрээний орлогыг тухайн тайлант үеийн туршид гарсан нөхөгдөх өртөг зардлыг лавлагаа болгосноор хүлээн зөвшөөрнө. Энэхүү нөхөгдөх өртөг зардлыг тухайн өдөр хүртэл гарсан нөхөгдөх өртөг зардлыг гэрээний тооцоолсон нөхөгдөх нийт өртөг зардалд харьцуулсан хувь хэмжээгээр хэмжинэ.

#### *Арилжааны гэрээ*

ХЗУ4. Тогтмол үнэтэй барилгын гэрээний орлогыг гэрээ тус бүрийн хувьд тухайн өдөр хүртэл зарцуулсан хөдөлмөр цагийг тооцоолсон нийт хөдөлмөр цагт харьцуулсан хувийн жинг лавлагаа болгосноор хэмждэг гүйцэтгэлийн хувийн жингийн аргын дагуу хүлээн зөвшөөрнө.

ХЗУ5. Өртөг нэмэх буюу өртөгт суурилсан гэрээний орлогыг тухайн тайлант үеийн туршид гарсан нөхөгдөх өртөг зардал дээр олсон төлбөрийг нэмсэн дүнг лавлагаа болгосноор хүлээн зөвшөөрнө. Энэхүү нөхөгдөх өртөг зардал ба олсон төлбөрийн нийт дүнг тухайн өдөр хүртэл гарсан өртөг зардлыг гэрээний тооцоолсон нийт өртөг зардалд харьцуулсан хувь хэмжээгээр хэмжинэ.

## Гэрээний орлого ба зардлын тодорхойлолт

ХЗУ6. Арилжааны болон арилжааны бус барилгын гэрээг дараах жишээгээр авч үзсэн. Гэрээний иж бүрдлийн үе шат болон гэрээний орлого, зардлыг хүлээн зөвшөөрөх хугацааг тодорхойлох нэгэн аргыг энэхүү жишээнд үлгэрчлэн харуулсан болно (энэ Стандартын 30 ба 43-р параграфыг үзнэ үү).

### *Арилжааны бус гэрээ*

ХЗУ7. Ажил, Үйлчилгээний Алба (барилгын гэрээ гүйцэтгэгч) нь Авто Зам ба Хурдны Замын Албанд зориулан гүүр барьж өгөх гэрээ байгуулсан. Ажил, Үйлчилгээний Алба нь төсвийн хуваарилалтаар санхүүждэг. Уг барилгын гэрээнд тухайн барилгын ажлын шаардлагууд, үүн дотроо тооцоолсон өртөг зардал, техникийн шаардлага, дуусгах хугацааг заасан боловч барилгын өртөг зардлыг Авто Зам ба Хурдны Замын Албанаас шууд нөхөн олгох талаар дурдаагүй. Энэхүү барилгын гэрээ нь гүүрний зураг төсөл ба барилгын чанарыг илэрхийлэх, удирдлагын төлөвлөлт ба хариуцлагын үндсэн баримт бичиг юм. Төсөвлөсөн өртгийн үзүүлэлтүүдийн хүрээнд тохиролцсон техникийн шаардлага бүхий үйлчилгээг үзүүлэх уг гэрээлэгч талуудын гүйцэтгэлийг үнэлэхдээ орц өгөгдөл болгон үүнийг ашиглах юм.

ХЗУ8. Гэрээний өртөг зардлын анхны тооцоолсон дүн нь 8,000 байсан. Гүүрийг гурван жилийн хугацаанд барьж байгуулна. Тусламжийн агентлаг нь уг барилгын гэрээнд заасан барилгын өртөг зардлын тэн хагас буюу 4,000-ын санхүүжилт олгохыг зөвшөөрсөн.

ХЗУ9. Нэг дэх жилийн эцэст уг гэрээний өртөг зардлын тооцоолсон дүн нь 8,050 болж нэмэгдсэн. Тусламжийн агентлаг нь тооцоолсон өртгийн энэхүү өсөлтийн тэн хагасыг санхүүжүүлэхийг зөвшөөрсөн.

ХЗУ10. Хоёр дахь жилийн эцэст, Авто Зам ба Хурдны Замын Албаны зөвлөмжийн дагуу Засгийн газар нь гэрээний тооцоолсон өртөг зардлыг 150-аар нэмэгдүүлэх өөрчлөлтийг зөвшөөрөн баталсан. Тусламжийн агентлаг нь энэхүү өөрчлөлтийн 50 хувийг санхүүжүүлэхийг зөвшөөрсөн. Хоёр дахь жилийн эцсийн байдлаар гарсан өртөг зардалд тухайн төслийг хэрэгжүүлэхийн тулд гурав дахь жилд ашиглах бөгөөд барилгын талбайд авчирч хадгалсан 100-ийн өртөг бүхий стандарт материал тусгагдсан байна.

ХЗУ11. Ажил, Үйлчилгээний Алба нь тухайн өдөр хүртэл гүйцэтгэсэн ажлын хувьд зарцуулсан гэрээний өртөг зардлыг хамгийн сүүлийн байдлаар тооцоолсон гэрээний нийт өртөг зардалд харьцуулсан хувь хэмжээг ашиглан тооцсоноор уг гэрээний иж бүрдлийн үе шатыг тодорхойлдог.



БАРИЛГЫН ГЭРЭЭ

ХЗУ12. Тухайн барилгын ажлын явц дахь санхүүгийн хураангуй мэдээ дараах байдалтай байна:

	Жил-1	Жил-2	Жил-3
Гэрээгээр тохиролцсон орлогын анхны дүн	4,000	4,000	4,000
Өөрчлөлт	-	100	100
Гэрээний нийт орлого	4,000	4,100	4,100
Тухайн өдөр хүртэл гарсан гэрээний өртөг зардал	2,093	6,168	8,200
Гэрээг дуусгах өртөг зардал	5,957	2,032	-
Гэрээний тооцоолсон нийт өртөг зардал	8,050	8,200	8,200
Иж бүрдлийн үе шат	26%	74%	100%

ХЗУ13. Гурав дахь жилд ашиглахын тулд барилгын талбайд хадгалсан 100-гийн стандарт материалыг тухайн өдөр хүртэл гүйцэтгэсэн ажлын хувьд гарсан барилгын өртөг зардлаас хассанаар хоёр дахь жилийн иж бүрдлийн үе шат (74%)-ыг тодорхойлсон.

ХЗУ14. Гурван жилийн санхүүгийн үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрсөн гэрээний орлого ба зардлын дүнг доор харуулав:

	Тухайн өдөр хүртэлх	Өмнөх жилүүдэд хүлээн зөвшөөрсөн	Тайлант жилд хүлээн зөвшөөрсөн
<b>Жил-1</b>			
Орлого (4,000 x 0.26)	1,040		1,040
Зардал (8,050 x 0.26)	2,093		2,093
<b>Жил-2</b>			
Орлого (4,100 x 0.74)	3,034	1,040	1,994
Зардал (8,200 x 0.74)	6,068	2,093	3,975
<b>Жил-3</b>			
Орлого (4,100 x 1.00)	4,100	3,034	1,066
Зардал (8,200 x 1.00)	8,200	6,068	2,132

*Арилжааны гэрээ*

ХЗУ15. Ихэнхдээ төсвийн хуваарилалтаар санхүүждэг боловч Ажил, Үйлчилгээний Алба (гэрээ гүйцэтгэгч) нь хувийн хэвшлийн байгууллагатай арилжааны сууриар цөөн тооны барилгын ажлыг гүйцэтгэх эрхтэй байдаг. Сайдын зөвшөөрсөний дагуу тус Алба нь гүүр барих 9,000-ийн тогтмол үнэтэй арилжааны гэрээ байгуулсан.

БАРИЛГЫН ГЭРЭЭ

ХЗУ16. Гэрээгээр тохиролцсон орлогын анхны дүн нь 9,000 байсан. Гэрээ гүйцэтгэгчийн тооцоолсон уг гэрээний анхны өртөг зардал нь 8,000 байв. Гүүрийг гурван жилийн хугацаанд барьж байгуулна.

ХЗУ17. Нэг дэх жилийн эцэст тус Алба нь гэрээний тооцоолсон өртөг зардлыг 8,050 болгож нэмэгдүүлсэн.

ХЗУ18. Хоёр дахь жилд, захиалагч нь гэрээний орлогыг 200-аар нэмэгдүүлэх өөрчлөлтийг зөвшөөрсөн бөгөөд түүний тооцоолсон нэмэлт зардал нь 150 байсан. Хоёр дахь жилийн эцсийн байдлаар гарсан өртөг зардалд тухайн төслийг хэрэгжүүлэхийн тулд гурав дахь жилд ашиглах бөгөөд барилгын талбайд авчирч хадгалсан 100-ийн өртөг бүхий стандарт материал тусгагдсан байна.

ХЗУ19. Тус Алба нь тухайн өдөр хүртэл гүйцэтгэсэн ажлын хувьд зарцуулсан гэрээний өртөг зардлыг хамгийн сүүлийн байдлаар тооцоолсон гэрээний нийт өртөг зардалд харьцуулсан хувь хэмжээг ашиглан тооцсоноор уг гэрээний иж бүрдлийн үе шатыг тодорхойлдог. Тухайн барилгын ажлын явц дахь санхүүгийн хураангуй мэдээ дараах байдалтай байна:

	Жил-1	Жил-2	Жил-3
Гэрээгээр тохиролцсон орлогын анхны дүн	9,000	9,000	9,000
Өөрчлөлт	-	200	200
Гэрээний нийт орлого	9,000	9,200	9,200
Тухайн өдөр хүртэл гарсан гэрээний өртөг зардал	2,093	6,168	8,200
Гэрээг дуусгах өртөг зардал	5,957	2,032	-
Гэрээний тооцоолсон нийт өртөг зардал	8,050	8,200	8,200
Тооцоолсон ашиг	950	1,000	1,000
Иж бүрдлийн үе шат	26%	74%	100%

ХЗУ20. Гурав дахь жилд ашиглахын тулд барилгын талбайд хадгалсан 100-гийн стандарт материалыг тухайн өдөр хүртэл гүйцэтгэсэн ажлын хувьд гарсан барилгын өртөг зардлаас хассанаар хоёр дахь жилийн иж бүрдлийн үе шат (74%)-ыг тодорхойлсон.

ХЗУ21. Гурван жилийн санхүүгийн үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрсөн гэрээний орлого, зардал ба ашгийн дүнг доор харуулав:

БАРИЛГЫН ГЭРЭЭ

	Тухайн өдөр хүртэлх	Өмнөх жилүүдэд хүлээн зөвшөөрсөн	Тайлант жилд хүлээн зөвшөөрсөн
<b>Жил-1</b>			
Орлого (9,000 x 0.26)	2,340		2,340
Зардал (8,050 x 0.26)	2,093		2,093
Ашиг	247		247
<b>Жил-2</b>			
Орлого (9,200 x 0.74)	6,808	2,340	4,468
Зардал (8,200 x 0.74)	6,068	2,093	3,975
Ашиг	740	247	493
<b>Жил-3</b>			
Орлого (9,200 x 1.00)	9,200	6,808	2,392
Зардал (8,200 x 1.00)	8,200	6,068	2,132
Ашиг	1,000	740	260

### Гэрээний тодруулга

*Төсвийн хуваарилалт/Тусламжаар санхүүжүүлсэн гэрээ болон Өртөг бүрэн нөхөх гэрээ*

ХЗУ22. Засгийн газрын бусад байгууллагуудад зориулан гүйцэтгэх гол барилга болон замын барилгын ажлыг удирдан зохицуулах байгууллага байдлаар Ажил, Үйлчилгээний Албыг саяхан байгуулсан. Энэ нь ихэвчлэн төсвийн хуваарилалтаар санхүүждэг боловч үндэсний буюу олон улсын тусламжийн агентлагийн санхүүжүүлэх барилгын төслүүдийг Сайдын зөвшөөрсөний дагуу гүйцэтгэх бүрэн эрхийг тус Албанд олгосон. Уг Алба нь өөрөө барилга барих хүчин чадалтай, түүнчлэн туслан гүйцэтгэх гэрээ байгуулж болох юм. Сайдын зөвшөөрсөний дагуу тус Алба нь улсын секторын худалдаа арилжааны байгууллагууд болон хувийн хэвшлийн байгууллагуудтай арилжааны барилгын гэрээ хийх, түүнчлэн улсын эмнэлэг, их дээд сургуультай өртгийг бүрэн нөхөх барилгын гэрээ байгуулах бүрэн эрхтэй байдаг.

ХЗУ23. Ажил, Үйлчилгээний Алба нь өөрийн эхний жилийн үйл ажиллагааг явуулж дууссан. Тус Албаны гэрээний гарсан бүх өртөг зардал нь мөнгөөр төлөгддөг бөгөөд явцын бүх нэхэмжлэлүүдээ (барилгын ажлыг санхүүжүүлэх тусламжийн агентлагуудад гаргасан) мөнгөөр хүлээн авсан. Барилгын ажилд зориулан тухайн тайлант үеийн туршид уг Албанд ямар нэг урьдчилгаа олгоогүй. Б ба В гэрээний хувьд гарсан гэрээний өртөг зардалд тэдгээр гэрээнд зориулан худалдан авсан боловч тухайн өдөр хүртэлх гэрээний гүйцэтгэлд хараахан ашиглаагүй байгаа материалын өртөг тусгагдсан байна. Тухайн жилд ямар нэг арилжааны гэрээ байгуулаагүй. (Арилжааны гэрээний жишээг доор харуулсан.)

## БАРИЛГЫН ГЭРЭЭ

- Ерөнхий зориулалттай орлогын төсвийн хуваарилалтаар А гэрээг санхүүжүүлсэн. (“Гэрээний орлого” гэж тодорхойлсон заалт уг гэрээнд байхгүй.)
- Б гэрээг Боловсролын газар болон тухайн барилгын өртөг зардлын 50 хувийг санхүүжүүлэх ХХ тусламжийн агентлагтай байгуулсан. (Гэрээний өртөг зардлын 50 хувийг тус гэрээний талууд нөхөн олгох учраас “гэрээний орлого” гэж тодорхойлсон.)
- В гэрээг бүхэлд нь Үндэсний Их Сургууль санхүүжүүлсэн. (Гэрээний бүх өртөг зардлыг Үндэсний Их Сургууль нь өөрийн барилгын үндсэн сангаас нөхөн олгоно гэдгийг уг гэрээний нөхцөлд тусгайлан заасан. Иймээс уг тодорхойлсон “гэрээний орлого” нь гэрээний өртөг зардалтай тэнцүү байна.)

ХЗУ24. Нэг дэх жилийн эцэст эдгээр гурван гэрээний явцын төлөв байдал дараах байдалтай байна:

	Гэрээ			Нийт дүн
	А	Б	В	
30-р параграфын дагуу хүлээн зөвшөөрсөн гэрээний орлого	-	225	350	575
30-р параграфын дагуу хүлээн зөвшөөрсөн гэрээний зардал	110	450	350	910
Төсвийн хуваарилалтаар санхүүжүүлсэн гэрээний өртөг зардал	110	225	-	335
Тайлант үед гарсан гэрээний өртөг зардал	110	510	450	1,070
- зардал гэж хүлээн зөвшөөрсөн (параграф 30)	110	450	350	910
- хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн (параграф 35)	-	60	100	160
Гэрээний орлого (дээр дурдсаныг үз)	-	225	350	575
Явцын нэхэмжлэл (52-р параграф)	-	225	330	555
Нэхэмжлээгүй гэрээний орлого	-	-	20	20
Урьдчилгаа (52-р параграф)	-	-	-	-

Энэхүү Стандартын дагуу тодруулах дүнгүүд нь дараах байдалтай байна:

БАРИЛГЫН ГЭРЭЭ

Тайлант үед орлого гэж хүлээн зөвшөөрсөн гэрээний орлого (50(а) параграф)	575
Тухайн өдөр хүртэл гарсан гэрээний өртөг зардал (51(а) параграф) (хүлээн зөвшөөрсөн ашиг/хасах: хүлээн зөвшөөрсөн алдагдал байхгүй)	1,070
Гэрээт ажлын хувьд уг гэрээний захиалагчдаас хүлээн авах нийт дүн (54-р параграфын дагуу тодорхойлсон ба 53(а) параграфын дагуу хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн)	150

51(а) ба 53(а) параграфын дагуу тодруулах дүнгүүд нь дараах байдалтай байна (Жич: Б гэрээний хувьд гэрээний орлого нь гэрээний өртөг зардлын 50 хувь байна):

	Гэрээ			Нийт дүн
	А	Б	В	
Гарсан гэрээний өртөг зардал	110	510	450	1,070
Явцын нэхэмжлэл	0	225	330	555
Тусламжийн агентлаг болон захиалагчдаас авах дүн	-	30	120	150

ХЗУ25. Тодруулга нь үйл ажиллагааны эхний жилд хамааралтай учраас 51(а) параграфын дагуу тодруулсан дүн нь тухайн тайлант үеийн дүнтэй ижил байна.

*Арилжааны гэрээ*

ХЗУ26. Өөрийн санаачлагаар ба Сайдын зөвшөөрсөний дагуу улсын секторын худалдаа арилжааны байгууллагууд болон хувийн хэвшлийн байгууллагуудтай арилжааны сууриар барилгын ажлыг гүйцэтгэх Үндэсний Барилгын Ажлын Хэлтсийг уг Ажил, Үйлчилгээний Албаны доор байгуулсан. Тус Хэлтэс нь өөрийн эхний жилийн үйл ажиллагааг явуулж дууссан. Тус Хэлтсийн гэрээний гарсан бүх өртөг зардал нь мөнгөөр төлөгддөг бөгөөд явцын бүх нэхэмжлэлүүд болон урьдчилгааг мөнгөөр хүлээн авсан. Б, В, Д гэрээний хувьд гарсан гэрээний өртөг зардалд тэдгээр гэрээнд зориулан худалдан авсан боловч тухайн өдөр хүртэлх гэрээний гүйцэтгэлд хараахан ашиглаагүй байгаа материалын өртөг тусгагдсан байна. Хэдийгээр ажлыг хараахан хийж гүйцэтгээгүй байгаа боловч Б, В, Д гэрээний захиалагч нар нь тухайн гэрээ гүйцэтгэгчид урьдчилгаа олгосон.

БАРИЛГЫН ГЭРЭЭ

ХЗУ27. Нэг дэх жилийн эцэст эдгээр таван гэрээний явцын төлөв байдал дараах байдалтай байна:

	Гэрээ					Нийт дүн
	А	Б	В	Г	Д	
30-р параграфын дагуу хүлээн зөвшөөрсөн гэрээний орлого	145	520	380	200	55	1,300
30-р параграфын дагуу хүлээн зөвшөөрсөн гэрээний зардал	110	450	350	250	55	1,215
44-р параграфын дагуу хүлээн зөвшөөрөх, хүлээгдэж буй алдагдал	-	-	-	40	30	70
Хүлээн зөвшөөрсөн ашиг, хасах нь: хүлээн зөвшөөрсөн алдагдал	35	70	30	(90)	(30)	15
Тайлант үед гарсан гэрээний өртөг зардал	110	510	450	250	100	1,420
Тайлант үед 30-р параграфын дагуу гэрээний зардал гэж хүлээн зөвшөөрсөн, гэрээний гарсан өртөг зардал	110	450	350	250	55	1,215
Ирээдүйн үйл ажиллагаатай холбоотой бөгөөд 35-р параграфын дагуу хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн гэрээний өртөг зардал	-	60	100	-	45	205
Гэрээний орлого (дээр дурдсаныг үз)	145	520	380	200	55	1,300
Явцын нэхэмжлэл (52-р параграф)	100	520	380	180	55	1,235
Нэхэмжлээгүй гэрээний орлого	45	-	-	20	-	65
Урьдчилгаа (52-р параграф)	-	80	20	-	25	125

Энэхүү Стандартын дагуу тодруулах дүнгүүд дараах байдалтай байна:

Тайлант үед орлого гэж хүлээн зөвшөөрсөн гэрээний орлого (50(а) параграф)	1,300
Тухайн өдөр хүртэл гарсан гэрээний өртөг зардал ба хүлээн зөвшөөрсөн ашиг (хасах: хүлээн зөвшөөрсөн алдагдал) (51(а) параграф)	1,435
Хүлээн авсан урьдчилгаа (51(б) параграф)	125
Гэрээт ажлын хувьд захиалагчдаас хүлээн авах нийт дүн-53(а) параграфын дагуу хөрөнгө гэж толилуулсан	220
Гэрээт ажлын хувьд захиалагчдад төлөх нийт дүн-53(б) параграфын дагуу хөрөнгө гэж толилуулсан	(20)

БАРИЛГЫН ГЭРЭЭ

51(а), 53(а), 53(б) параграфын дагуу тодруулах дүнгүүдийг дараах байдлаар тооцоолсон:

	Гэрээ					Нийт дүн
	А	Б	В	Г	Д	
Гэрээний гарсан өртөг зардал	110	510	450	250	100	1,420
Хүлээн зөвшөөрсөн ашиг, хасах нь: хүлээн зөвшөөрсөн алдагдал	35	70	30	(90)	(30)	15
	145	580	480	160	70	1,435
Явцын нэхэмжлэл	100	520	380	180	55	1,235
Захиалагчдаас авах дүн	145	60	100	-	15	220
Захиалагчдад төлөх дүн	-	-	-	(20)	-	(20)

ХЗУ28. Тодруулга нь үйл ажиллагааны эхний жилд хамааралтай учраас 51(а) параграфын дагуу тодруулсан дүн нь тухайн тайлант үеийн дүнтэй ижил байна.

## НББОУС 11-ТЭЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 11, *Барилгын Гэрээ*-г НББОУС 11, *Барилгын Гэрээ*-нээс үндсэндээ бэлтгэсэн болно. УСНББОУС 11 ба НББОУС 11-ийн хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- Улсын секторын байгууллагуудын нягтлан бодох бүртгэлд уг стандартын мөрдөгдөх боломжтой байдлыг тодруулахын тулд НББОУС 11-д тусгаснаас гадна нэмэлт тайлбаруудыг УСНББОУС 11-д тусган оруулсан.
- УСНББОУС 11 нь зарим тохиолдолд НББОУС 11-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь УСНББОУС 11 дэх “орлого” /revenue/, “санхүүгийн үр дүнгийн тайлан” гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. НББОУС 11 дэх адилтгах нэр томъёо нь “орлого” /income/, “орлогын тайлан” юм.
- УСНББОУС 11 нь түүний цар хүрээнд хамаарах боловч хууль ёсны гэрээ хэлбэртэй биш, заавал биелүүлэх хэлцлийг агуулсан байдаг.
- УСНББОУС 11 нь өртөгт суурилсан болон арилжааны бус гэрээг агуулдаг бөгөөд эдгээр нь түүний цар хүрээнд хамаарна.
- Гэрээний өртөг зардал нь гэрээний нийт орлогоос давж хэтрэх нилээд их магадлалтай болсон үед гэрээгээр хүлээгдэж буй алдагдлыг нэн даруй хүлээн зөвшөөрөх талаархи шаардлага нь гэрээний өртөг зардлыг тухайн гэрээний талуудаас бүрэн нөхөхөөр уг гэрээний эхэнд төлөвлөсөн зөвхөн тийм гэрээнүүдэд хамааран мөрдөгдөнө гэдгийг УСНББОУС 11-ээр тодорхой ойлгомжтой болгосон байдаг.
- Арилжааны бус барилгын гэрээнд уг Стандартыг хэрхэн мөрдөхийг үлгэрчлэн харуулсан нэмэлт жишээг УСНББОУС 11-д тусгасан.



## УСНББОУС 12–БАРАА МАТЕРИАЛ

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) 2, *Бараа Материал* (2003 онд хянан засварласан)-аас үндсэндээ бэлтгэсэн болно. НББОУС 2-оос авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон EC4M 6XH, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)

Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.

## УСНББОУС 12-САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЛИЛУУЛГА

### УСНББОУС-ын түүх

Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

УСНББОУС 12, Бараа Материал-ыг 2001 оны 7 дугаар сард гаргасан.

2006 оны 12 дугаар сард УСНББОУСЗ нь хянан засварласан УСНББОУС 12-ыг гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 12-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2011-ийн Сайжруулалтууд (2011 оны 10 дугаар сард гаргасан)
- УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба Хэмжилт (2010 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 27, Хөдөө Аж Ахуй (2009 оны 12 дугаар сард гаргасан)
- УСНББОУС-ын Сайжруулалтууд (2010 оны 11 дүгээр сард гаргасан)

### УСНББОУС 12-ын нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт

Өөрчлөгдсөн параграф	Хэрхэн өөрчилсөн	Юугаар өөрчилсөн
Танилцуулга хэсэг	Хассан	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
2	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 27, 2009 оны 12-р сар УСНББОУС 29, 2010 оны 01-р сар
4	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
5	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
12	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
14А	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
15	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
29	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 27, 2009 оны 12-р сар

БАРАА МАТЕРИАЛ

33	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
51А	Шинэ	УСНББОУС 27, 2009 оны 12-р сар
51Б	Шинэ	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
51В	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
51Г	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
52	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар

**УСНББОУС 12–БАРАА МАТЕРИАЛ**

**АГУУЛГА**

	Параграф
Зорилго	1
Цар хүрээ	2-8
Тодорхойлолт	9-14
Цэвэр боломжит үнэ цэнэ	10
Бараа материал	11-14
Бараа материалын хэмжилт	15-43
Бараа материалын өртөг	18-31
Худалдан авалтын өртөг	19
Хувиргалтын зардал	20-23
Бусад зардал	24-27
Үйлчилгээний байгууллагын бараа материалын өртөг	28
Биологийн хөрөнгөөс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний өртөг	29
Өртгийн хэмжилтийн арга зүй	30-31
Өртгийн томъёолол	32-37
Цэвэр боломжит үнэ цэнэ	38-42
Барааг үнэгүй эсвэл нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилах	43
Зардал гэж хүлээн зөвшөөрөх	44-46
Тодруулга	47-50
Хүчин төгөлдөр болох хугацаа	51-52
УСНББОУС 12 (2001)-оос татгалзах	53
Дүгнэлтийн үндэслэл	
НББОУС 12-той харьцуулалт	

## БАРАА МАТЕРИАЛ

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 12, *Бараа Материал*-ыг 1-53-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 12-ыг түүний зорилгын агуулга, Дүгнэлтийн Үндэслэл, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

1. Энэ Стандартын зорилго нь бараа материалыг бүртгэх нягтлан бодох бүртгэлийн арга хандлагыг тодорхойлоход оршино. Бараа материалын нягтлан бодох бүртгэлийн үндсэн асуудал нь хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх ба холбогдох орлогыг хүлээн зөвшөөрөх хүртэл дараагийн үеүдэд тусгах өртгийн дүнг тодорхойлох явдал байдаг. Энэхүү Стандарт нь өртгийг тодорхойлох, түүнчлэн түүнийг дараа нь зардал гэж хүлээн зөвшөөрөх, үүн дотроо цэвэр боломжит үнэ цэнэ хүртэл бууруулах талаархи заавар удирдамжаар хангадаг. Мөн энэ Стандарт нь өртгийг бараа материалд шингээн хуваарилах өртгийн томъёоллын талаархи заавар удирдамжаар хангадаг.

## Цар хүрээ

2. Нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар санхүүгийн тайлангаа бэлтгэн толилуулж буй байгууллага нь доор дурдсанаас бусад бүх бараа материалд энэ Стандартыг мөрдөнө:
  - (а) Барилгын гэрээний, түүнчлэн шууд холбоотой үйлчилгээний гэрээний дагуу үүссэн дуусаагүй үйлдвэрлэл (УСНББОУС 11, *Барилгын Гэрээ-г үзнэ үү*);
  - (б) Санхүүгийн хэрэглүүр (УСНББОУС 28, *Санхүүгийн хэрэглүүр: Толилуулга ба УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт-ийг үзнэ үү*);
  - (в) Хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой биологийн хөрөнгө ба үр шим хүртэх үеийн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн (УСНББОУС 27, *Хөдөө Аж Ахуй-г үзнэ үү*); ба
  - (г) Үйлчилгээг хүлээн авагчаас хариуд нь төлбөр шууд авахгүй эсвэл нэрлэсэн төлбөр авснаар нийлүүлэх үйлчилгээний дуусаагүй үйлдвэрлэл.
3. Дараах этгээдийн эзэмшиж буй бараа материалын хэмжилтэнд энэ Стандартыг мөрдөхгүй:
  - (а) Тухайн салбарт нийтлэг тогтсон нягтлан бодох бүртгэлийн практикын дагуу цэвэр боломжит үнэ цэнээр нь хэмждэг хөдөө аж ахуйн болон ойн аж ахуйн бүтээгдэхүүн, үр шим авалтын дараах хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, ашигт малтмалын бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид. Эдгээр бараа материалыг цэвэр боломжит үнэ цэнээр нь хэмждэг тохиолдолд уг үнэ цэнийн өөрчлөлтийг тухайн өөрчлөлт гарсан тайлант үед ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.
  - (б) Борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээр өөрсдийн бараа материалыг хэмжиж бүртгэдэг түүхий эдийн брокер-худалдаачид. Ийм бараа материалыг түүний борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээр нь хэмждэг тохиолдолд уг

**борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тухайн өөрчлөлт гарсан тайлант үед ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.**

4. [Хассан]
5. [Хассан]
6. Дээрх 2(г) параграфт дурдсан бараа материал нь цаашид анхаарал хандуулахыг шаардах улсын секторын тусгай асуудалтай холбоотой учраас НББОУС 2, *Бараа Материал*-д тусгагдаагүй бөгөөд энэ Стандартын цар хүрээнд оруулаагүй болно.
7. Дээрх 3(а) параграфт дурдсан бараа материалыг түүний үйлдвэрлэлийн тодорхой үе шатанд цэвэр боломжит үнэ цэнээр нь хэмждэг. Тухайлбал, (а) хөдөө аж ахуйн ургацыг хураан авах буюу ашигт малтмалыг олборлох ба форвард гэрээ болон засгийн газрын баталгааны дагуу борлуулалт нь баталгаатай байх, эсвэл (б) идэвхитэй зах зээл бэлэн байгаа бөгөөд үл борлогдох эрсдэл маш бага байх тохиолдолд ингэж хэмжинэ. Эдгээр бараа материал нь энэ Стандартын зөвхөн хэмжилтийн шаардлагуудаас чөлөөлөгдөнө.
8. Брокер-худалдаачид гэдэг нь түүхий эдийг бусдын өмнөөс эсвэл өөрсдөө эрсдлээ хариуцан худалдан авч, борлуулдаг этгээдүүд юм. 3(б) параграфт дурдсан бараа материалыг ихэвчлэн ойрын ирээдүйд худалдан борлуулж, үнийн хэлбэлзэл эсвэл брокер-худалдаачдын нэмсэн зөрүүгээс ашиг олох зорилгоор худалдан авдаг. Ийм бараа материалыг түүний борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээр нь хэмждэг тохиолдолд энэ Стандартын зөвхөн хэмжилтийн шаардлагуудаас чөлөөлөгдөнө.

## **Тодорхойлолт**

9. **Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:**

**Одоогийн орлуулалтын өртөг** гэдэг нь тайлангийн өдрөөр тухайн хөрөнгийг олж эзэмшихийн тулд байгууллагын зарцуулах байсан өртөг юм.

**Бараа материал** гэдэг нь дараах хөрөнгүүд юм:

- (а) Үйлдвэрлэлийн процессод ашиглан зарцуулагдах материал буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа;
- (б) Үйлчилгээ үзүүлэхэд ашиглан зарцуулах буюу түгээн хуваарилагдах материал буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа;
- (в) Хэвийн үйл ажиллагааны явцад худалдан борлуулах буюу түгээн хуваарилах зорилгоор эзэмшиж байгаа;

- (г) **Борлуулах буюу түгээн хуваарилахын тулд үйлдвэрлэлийн процессод байгаа.**

**Цэвэр боломжит үнэ цэнэ** гэдэг нь хэвийн үйл ажиллагааны явцад борлуулахаар тооцсон үнээс түүнийг иж бүрдэл болгох ба борлуулах, сольж арилжих буюу түгээн хуваарилахад шаардлагатай тооцоолсон өртөг, зардлыг хассан дүн юм.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д дахин нийтэлсэн болно.

### **Цэвэр боломжит үнэ цэнэ**

10. Цэвэр боломжит үнэ цэнэ нь хэвийн үйл ажиллагааны явцад бараа материалыг борлуулснаар хэрэгжүүлнэ гэж уг байгууллагын хүлээж буй цэвэр дүнг илэрхийлдэг. Бодит үнэ цэнэ нь зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа худалдан авагчид болон борлуулагчдын хооронд ижил бараа материалыг зах зээл дээр арилжиж болох үнийг илэрхийлдэг. Цэвэр боломжит үнэ цэнэ нь тухайн байгууллагаас хамааралтай үнэ цэнэ; харин бодит үнэ цэнэ нь байгууллагаас хамааралгүй байдаг. Бараа материалын цэвэр боломжит үнэ цэнэ нь борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэтэй тэнцүү биш байж болно.

### **Бараа материал**

11. Бараа материал нь худалдан авсан болон буцаан борлуулахаар эзэмшиж байгаа барааг өөртөө агуулдаг. Үүнд тухайлбал; байгууллагын худалдан авсан ба буцаан борлуулахаар эзэмшиж буй бараа эсвэл борлуулах зорилгоор эзэмшиж буй газар болон бусад үл хөдлөх хөрөнгө хамаарна. Мөн бараа материалд тухайн байгууллагын үйлдвэрлэсэн бэлэн бүтээгдэхүүн болон дуусаагүй үйлдвэрлэл багтдаг. Бараа материалд мөн (а) үйлдвэрлэлд ашиглахаар хүлээгдэж буй материал ба хангамжийн зүйлс, (б) бусад талуудад үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгөөр түгээн хуваарилахын тулд байгууллагын худалдан авсан буюу үйлдвэрлэсэн бараа хамаарна. Жишээлбэл; эрүүл мэндийн эрх бүхий байгууллагаас сургуулиудад хандив болгон олгохоор үйлдвэрлэсэн боловсролын ном материал. Улсын секторын олон байгууллагуудын хувьд бараа материал нь буцаан борлуулахын тулд худалдан авч эзэмшиж буй бараа, борлуулах зорилгоор үйлдвэрлэсэн бараанаас илүүтэйгээр үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой байдаг. Үйлчилгээний байгууллагын хувьд, 28-р параграфт заасанчлан, холбогдох орлогыг нь тухайн байгууллага харахан хүлээн зөвшөөрөөгүй байгаа үйлчилгээний өртөг нь бараа материалд хамаардаг (орлогын хүлээн зөвшөөрөлтийн талаархи заавар удирдамжийг УСНББОУС 9, *Арилжааны Ажил Гүйлгээний Орлого*-оос үзэж болно).



12. Улсын секторын бараа материалд дараах зүйлс хамаарч болно:
- (а) Цэргийн тоног төхөөрөмж;
  - (б) Барааны агуулах;
  - (в) Засвар, үйлчилгээний материал;
  - (г) Үндсэн хөрөнгийн стандартад хамаарахаас бусад, үндсэн хөрөнгийн сэлбэг хэрэгсэл;
  - (д) Стратегийн нөөц (жишээлбэл; эрчим хүчний нөөц);
  - (е) Гүйлгээнд гаргаагүй мөнгөн тэмдэгтийн нөөц;
  - (ж) Борлуулах зорилгоор эзэмшиж буй шуудангийн үйлчилгээний хангамжийн зүйлс (жишээлбэл; марк);
  - (и) Дуусаагүй үйлдвэрлэл, үүн дотроо:
    - (i) Боловсрол/сургалтын материал; ба
    - (ii) Үйлчилгээг холбоогүй талуудын ажил гүйлгээний үнээр борлуулдаг тохиолдолд үйлчлүүлэгчид үзүүлэх үйлчилгээ (жишээлбэл; аудитын үйлчилгээ); ба
  - (к) Борлуулах зорилгоор эзэмшиж буй газар/үл хөдлөх хөрөнгө.
13. Засгийн газар нь янз бүрийн хөрөнгүүдийн, үүн дотроо шуудангийн марк ба мөнгөн дэвсгэртийг үйлдвэрлэх ба гаргах эрхийг хянадаг тохиолдолд ийм зүйлсийг энэхүү Стандартын зорилгоор бараа материал гэж хүлээн зөвшөөрнө. Тухайн зүйлсийг түүнд тусгасан нүүрний буюу нэрлэсэн үнэ цэнээр тайлагнахгүй, харин 15-р параграфт заасанчлан, тэдгээрийг хэвлэх буюу үйлдвэрлэх өртгөөр хэмжинэ.
14. Засгийн газар нь аюул ослын буюу бусад нөхцөл байдалд (жишээлбэл; байгалийн гамшиг, иргэний хамгааллын бусад яаралтай нөхцөл байдалд) ашиглахын тулд эрчим хүчний нөөц (тухайлбал; газрын тос) гэх мэт төрөл бүрийн нөөц хөрөнгүүдийн стратегийн нөөцийг хадгалан бүрдүүлдэг тохиолдолд тэдгээр нөөцүүдийг энэ Стандартын зорилгоор бараа материал гэж хүлээн зөвшөөрч, зохих ёсоор бүртгэнэ.
- 14А. Цэргийн тоног төхөөрөмж нь зэвсэг буюу зэвсгийн системээр ажиллах сум, залуурт пуужин, тэсрэх пуужин, тэсрэх бодис гэх мэт нэг удаа ашиглах зүйлсээс бүрддэг. Гэвч зарим төрлийн залуурт пуужин нь УСНББОУС 17, *Үндсэн Хөрөнгө*-д заасан ангиллын шалуурыг хангаж байвал тэдгээрийг уг Стандартын дагуу тайлагнана.

## **Бараа материалын хэмжилт**

15. **16 эсвэл 17-р параграфыг мөрдөхөөс бусад тохиолдолд бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь хэмжинэ.**

16. **Бараа материалыг арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн тохиолдолд тэдгээрийн өртгийг тухайн олж эзэмшсэн өдрөөрх бодит үнэ цэнээр хэмжинэ.**
17. **Бараа материалыг дараах зорилгоор эзэмшиж буй тохиолдолд өртөг ба одоогийн орлуулалтын өртгийн аль багаар нь хэмжинэ:**
  - (а) **Үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилах; эсвэл**
  - (б) **Үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилах барааны үйлдвэрлэлийн процессод ашиглан зарцуулах.**

#### **Бараа материалын өртөг**

18. **Бараа материалын өртөг нь худалдан авалтын бүх өртөг зардал, хувиргалтын зардал болон тухайн бараа материалыг түүний одоогийн байршил ба төлөв байдалд оруулахтай холбогдож гарсан бусад зардлаас бүрддэг.**

#### *Худалдан авалтын өртөг*

19. Бараа материалын худалдан авалтын өртөг нь (а) худалдан авсан үнэ, (б) импортын татвар ба бусад татвар (татварын эрх бүхий байгууллагаас тухайн байгууллага дараа нь нөхөн авч болохоос бусад), (в) тээвэрлэлт, ачиж буулгах зардал болон бэлэн бүтээгдэхүүн, материал, үйлчилгээний худалдан авалтанд шууд хамаарах бусад зардлуудаас бүрддэг. Худалдан авалтын өртгийг тодорхойлохдоо худалдааны хөнгөлөлт, урамшуулал болон бусад адилтгах зүйлсийг хасна.

#### *Хувиргалтын зардал*

20. Дуусаагүй үйлдвэрлэлийг бэлэн бүтээгдэхүүн болгох хувиргалтын зардал нь үндсэндээ үйлдвэрлэлийн орчинд гардаг. Бараа материалын хувиргалтын зардал нь шууд хөдөлмөр гэх мэт бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шууд хамааралтай зардлуудаас бүрддэг. Мөн материалыг бэлэн бүтээгдэхүүн болгон хувиргахад гардаг үйлдвэрлэлийн тогтмол ба хувьсах нэмэгдэл зардлын системчилсэн хуваарилалт нь хувиргалтын зардалд хамаардаг. Үйлдвэрлэлийн тогтмол нэмэгдэл зардал нь (а) үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмжийн элэгдэл ба засварын зардал, (б) үйлдвэрийн удирдлага ба захиргааны зардал гэх мэт үйлдвэрлэлийн тоо хэмжээнээс үл хамааран харьцангуй тогтвортой байдаг үйлдвэрлэлийн шууд бус зардлууд юм. Үйлдвэрлэлийн хувьсах нэмэгдэл зардал нь үйлдвэрлэлийн тоо хэмжээнээс шууд эсвэл ойролцоогоор шууд хамааран өөрчлөгддөг шууд бус хөдөлмөр, шууд бус материалын зардал гэх мэт үйлдвэрлэлийн шууд бус зардлууд юм.
21. Үйлдвэрлэлийн тогтмол нэмэгдэл зардлыг хувиргалтын зардалд шингээх хуваарилалт нь тухайн үйлдвэрлэлийн хэрэгслийн хэвийн хүчин чадалд үндэслэдэг. Хэвийн хүчин чадал гэдэг нь төлөвлөсөн засвар үйлчилгээний улмаас гарах хүчин чадлын алдагдлыг харгалзаж хассан бөгөөд олон тайлант үеүд буюу улирлуудын дундажаар тооцоход, хэвийн нөхцөл

байдалд бий болгохоор хүлээгдэж буй үйлдвэрлэлийн тоо хэмжээ юм. Хэрэв үйлдвэрлэлийн бодит тоо хэмжээ нь хэвийн хүчин чадалтай ойролцоо байвал түүнийг тооцоололд ашиглаж болно. Үйлдвэрлэсэн нэгж бүтээгдэхүүнд хуваарилах тогтмол нэмэгдэл зардлын дүнг цөөн тоо хэмжээний үйлдвэрлэл эсвэл сул зогсолтын улмаас нэмэгдүүлэхгүй. Ийм хуваарилагдаагүй үлдсэн нэмэгдэл зардлыг тухайн зардал гарсан тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрнө. Хэвийн бус их хэмжээний үйлдвэрлэл явуулсан тайлант үеүдэд тухайн бүтээгдэхүүнийг өртгөөс өндөр дүнгээр хэмжин тусгахгүйн тулд үйлдвэрлэсэн нэгж бүтээгдэхүүнд хуваарилах үйлдвэрлэлийн тогтмол нэмэгдэл зардлын дүнг бууруулна. Үйлдвэрлэлийн хувьсах нэмэгдэл зардлыг уг үйлдвэрлэлийн хэрэгслийн бодит ашиглалтанд үндэслэн тухайн үйлдвэрлэсэн нэгж бүтээгдэхүүнд хуваарилдаг.

22. Тухайлбал; орон сууцны буюу арилжааны газар эзэмшилт байдлаар борлуулах зорилгоор эзэмшиж буй хөгжүүлээгүй газрыг боловсруулан хөгжүүлэхэд гаргасан тогтмол ба хувьсах аль аль зардлын хуваарилалт нь газрын гадаргуу, ус зайлуулах хоолой, ашиглалтын холболтонд зориулсан дамжуулах хоолой зэрэгтэй холбоотой зардлуудыг агуулсан байж болно.
23. Үйлдвэрлэлийн процессын явцад нэгээс олон тооны бүтээгдэхүүнийг нэгэн зэрэг үйлдвэрлэж болох юм. Тухайлбал; хамсарсан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг эсвэл үндсэн ба дайвар бүтээгдэхүүнтэй байх үед ийм тохиолдол үүсдэг. Бүтээгдэхүүн тус бүрийн хувиргалтын зардлыг тусдаа тодорхойлох боломжгүй тохиолдолд хувиргалтын зардлыг оновчтой бөгөөд тогтвортой суурьт үндэслэн тэдгээр бүтээгдэхүүнүүдэд хуваарилна. Тухайлбал, бүтээгдэхүүнүүдийг тус тусад нь тодорхойлж чадах үйлдвэрлэлийн процессын тодорхой нэг үе шатанд эсвэл үйлдвэрлэл дууссан үед бүтээгдэхүүн тус бүрийн борлуулалтын харгалзах үнэд үндэслэн ийм хуваарилалтыг хийж болно. Өөрийн шинж төрлийн дагуу ихэнх дайвар бүтээгдэхүүн нь материаллаг бус байдаг. Ийм материаллаг бус байх үед дайвар бүтээгдэхүүнийг ихэвчлэн цэвэр боломжит үнэ цэнээр хэмжих ба уг үнэ цэнийг үндсэн бүтээгдэхүүний өртгөөс хасдаг. Үүний үр дүнд үндсэн бүтээгдэхүүний дансны үнэ нь өөрийн өртгөөсөө материаллаг хэмжээгээр зөрүүтэй болохгүй юм.

#### *Бусад зардал*

24. Бараа материалыг түүний одоогийн байршил ба төлөв байдалд оруулахтай холбогдож гарсан зөвхөн тэр хэмжээгээр бусад зардлыг тухайн бараа материалын өртөгт оруулдаг. Жишээлбэл; үйлдвэрлэлийн бус нэмэгдэл зардал эсвэл тусгай худалдан авагчдад зориулж гаргасан бүтээгдэхүүний загварын зардлыг бараа материалын өртөгт оруулах нь тохиромжтой байж болно.
25. Бараа материалын өртөгт оруулдаггүй бөгөөд гарсан тайлант үед нь зардлаар хүлээн зөвшөөрдөг зардлын жишээнд дараах зүйлс хамаарна:

## БАРАА МАТЕРИАЛ

- (а) Хаягдал материал, хөдөлмөр буюу үйлдвэрлэлийн бусад зардлын хэвийн бус дүн;
  - (б) Үйлдвэрлэлийн дараагийн шат дамжлагад оруулахын өмнө тухайн үйлдвэрлэлийн процессод зайлшгүй гарах шаардлагатайгаас бусад хадгалалтын зардал;
  - (в) Бараа материалыг одоогийн байршил ба төлөв байдалд оруулахтай холбогдож гараагүй удирдлагын нэмэгдэл зардал; ба
  - (г) Борлуулалтын зардал.
26. УСНББОУС 5, *Зээлийн Өртөг* нь зээлийн зардлыг бараа материалын өртөгт оруулах хязгаарлагдмал нөхцлүүдийг тодорхойлсон байдаг.
27. Байгууллага нь бараа материалыг хойшлогдсон төлбөртэй нөхцлөөр худалдан авч болох юм. Уг гэрээний нөхцөл нь санхүүжилтийн элементийг зохих ёсоор агуулдаг тохиолдолд тэрхүү элементийг тухайлбал, хэвийн зээлийн нөхцлөөрх худалдан авалтын үнэ ба төлсөн дүнгийн хоорондох зөрүүг тухайн санхүүжилтийн хугацааны туршид хүүний зардлаар хүлээн зөвшөөрнө.

### *Үйлчилгээний байгууллагын бараа материалын өртөг*

28. Үйлчилгээний байгууллага нь бараа материалтай (2г) параграфт дурдсанаас бусад бараа материал) тохиолдолд, уг бараа материалыг түүнийг үйлдвэрлэлийн өртгөөр нь хэмжинэ. Үйлдвэрлэлийн өртөг нь юуны өмнө тухайн үйлчилгээг үзүүлэхэд шууд оролцох ажилтны, үүн дотроо хяналт тавих ажилтны хөдөлмөрийн болон бусад зардал, түүнчлэн хамааруулан хуваарилж болох нэмэгдэл зардлаас бүрдэнэ. Үйлчилгээ үзүүлэхэд оролцдоггүй ажилтны хөдөлмөрийн зардлыг өртөгт оруулахгүй. Борлуулалтын болон ерөнхий удирдлагын ажилтнуудтай холбоотой хөдөлмөрийн зардал ба бусад зардлыг өртөгт оруулахгүй, харин гарсан тайлант үед нь зардал гэж хүлээн зөвшөөрнө. Тухайн үйлчилгээний байгууллагын нэхэмжлэх үнэд ихэвчлэн нөлөө үзүүлэх хүчин зүйлс болох үнийн нэмэгдэл буюу хамааруулан хуваарилах боломжгүй нэмэгдэл зардал нь уг үйлчилгээний байгууллагын бараа материалын өртөгт хамаарахгүй.

### *Биологийн хөрөнгөөс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний өртөг*

29. Байгууллага нь өөрийн биологийн хөрөнгөөс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн болох бараа материалыг УСНББОУС 27-гийн дагуу анх хүлээн зөвшөөрөхдөө үр шим авалтын цэг дээрх түүний борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээр хэмждэг. Уг дүн нь энэ Стандартыг мөрдсөн өдрөөрх тухайн бараа материалын өртөг болно.

### *Өртгийн хэмжилтийн арга зүй*

30. Стандарт өртгийн арга, жижиглэнгийн арга гэх мэт бараа материалын өртгийн хэмжилтийн арга зүйнүүдээр тооцоолсон үр дүн нь өртөгтэй

ойролцоо байвал аль тохиромжтой аргыг сонгон хэрэглэж болно. Стандарт өртгийн арга нь материал ба хангамжийн зүйлс, хөдөлмөр, үр ашиг болон хүчин чадлын ашиглалтын хэвийн түвшингүүдийг харгалзан тусгадаг. Эдгээрийг тогтмол хугацаагаар нягталж шалгах ба хэрэв шаардлагатай бол одоогийн нөхцөл байдалд тохируулан өөрчилнө.

31. Бараа материалыг тухайн байгууллагад арилжааны бус ажил гүйлгээгээр шилжүүлж болох юм. Жишээлбэл; олон улсын тусламжийн агентлаг нь байгалийн гамшиг учирсаны дараа эмнэлгийн хангамжийн зүйлсийг улсын эмнэлэгт хандивлаж болох юм. Ийм нөхцөлд бараа материалын өртөг нь түүнийг олж авсан өдрөөрх уг хөрөнгийн бодит үнэ цэнэ байна.

### **Өртгийн томъёолол**

32. **Харилцан сольж орлуулах боломжгүй бараа материал, түүнчлэн тусгай төслүүдэд зориулан үйлдвэрлэсэн ба тусгаарласан бараа эсвэл үйлчилгээний өртгийг тэдгээрийн тус тусын өртгийн тусгайлан тэмдэглэлтийг ашигласнаар тодорхойлдог.**
33. Өртгийн тусгайлан тэмдэглэлт гэдэг нь тодорхой өртөг зардлуудыг бараа материалын уг ялган тодорхойлсон зүйлсэд шингээн хамааруулна гэсэн үг юм. Энэ нь худалдан авсан эсвэл өөрөө үйлдвэрлэсэн эсэхээс үл хамааран тусгай төсөлд зориулан тусгаарласан зүйлсийн хувьд хэрэглэхэд тохиромжтой арга юм. Гэхдээ харилцан сольж орлуулах боломжтой маш олон тооны бараа материалын зүйлс байгаа тохиолдолд өртгийн тусгайлан тэмдэглэх аргыг хэрэглэх нь тохиромжгүй байдаг. Ийм тохиолдолд, тайлант үеийн ашиг, алдагдалд уг урьдчилан тодорхойлсон хүчин зүйлсийн үзүүлэх үр нөлөөг тодорхойлохын тулд бараа материалын үлдэгдлээс сонголт хийх аргыг хэрэглэж болно.
34. **33-р параграфыг мөрдөх үедээ, байгууллага нь түүний хувьд ижил төсөөтэй шинж төрөл ба ашиглалт бүхий бүх бараа материалын хувьд өртгийн нэг ижил томъёоллыг (аргыг) ашиглана. Харин өөр шинж төрөл буюу ашиглалт бүхий бараа материалын (жишээлбэл; зарим бараа материалыг үйл ажиллагааны нэг сегментэд ашигладаг ба тухайн төрлийн бараа материалыг үйл ажиллагааны өөр сегментэд ашигладаг байх) хувьд өртгийн өөр томъёолол тохиромжтой гэдгийг илэрхийлж болох юм. Бараа материалын газарзүйн байршлын (болон холбогдох татварын зохицуулалтын) ялгаатай байдал нь өртгийн өөр томъёолол ашиглахыг зөвтгөн батлахад дангаараа хангалттай шалтгаан болж чадахгүй.**
35. **33-р параграфт дурдсанаас бусад бараа материалын өртгийг эхэлж авсныг эхэлж зарлагдах (ЭАЭЗ) эсвэл жинэлсэн дундаж өртгийн томъёоллыг ашигласнаар хуваарилдаг. Тухайн байгууллагын хувьд ижил төсөөтэй шинж төрөл ба ашиглалт бүхий бүх бараа материалд уг байгууллага нь өртгийн нэг ижил томъёоллыг (аргыг) ашиглана. Харин өөр шинж төрөл буюу ашиглалт бүхий бараа материалын**

**хувьд өртгийн өөр томъёолол тохиромжтой гэдгийг зөвтгөн баталж болох юм.**

36. Тухайлбал; үйл ажиллагааны нэг сегментэд ашиглагдаж буй бараа материал нь уг байгууллагын үйл ажиллагааны өөр сегментэд ашиглагдаж байгаа тухайн ижил төрлийн бараа материалаас өөр ашиглалтын зориулалттай байж болно. Гэхдээ бараа материалын газарзүйн байршлын ялгаатай байдал нь өртгийн өөр томъёолол ашиглахыг зөвтгөн батлахад дангаараа хангалттай шалтгаан болж чадахгүй юм.
37. ЭАЭЗ томъёолол нь эхлээд худалдан авсан бараа материалыг эхэлж борлуулна гэж төсөөлдөг бөгөөд иймээс тайлант үеийн эцэст үлдэж байгаа бараа материал нь хамгийн сүүлд худалдан авсан буюу үйлдвэрлэсэн зүйлс байх юм. Жинэлсэн дундаж өртгийн томъёоллын дагуу, тайлант үеийн эхэнд байсан ижил төрлийн бараа материал ба тухайн тайлант үеийн туршид худалдаж авсан буюу үйлдвэрлэсэн ижил төрлийн бараа материалын жинэлсэн дундаж өртгөөр тухайн бараа материал зүйл тус бүрийн өртгийг тодорхойлдог. Тухайн байгууллагын нөхцөл байдлаас хамааран жинэлсэн дундаж өртгийг үечилсэн байдлаар эсвэл нэмэлт татан авалтыг хүлээн авах бүрд тооцоолж болох юм.

### **Цэвэр боломжит үнэ цэнэ**

38. Бараа материал гэмтсэн, бүхэлдээ буюу хэсэгчлэн хоцрогдолд орсон, эсвэл тэдгээрийн борлуулалтын үнэ буурсан бол бараа материалын өртөг нь нөхөгдөхгүй болж болох юм. Мөн бараа материалыг иж бүрдэл болгох тооцоолсон зардал эсвэл борлуулах, сольж арилжих буюу түгээн хуваарилахад гарах тооцоолсон зардал өссөнөөр бараа материалын өртөг нөхөгдөхгүй байж болно. Бараа материалын өртгийг цэвэр боломжит үнэ цэнэ хүртэл бууруулах практик нь хөрөнгийг түүний борлуулалт, арилжаа, түгээн хуваарилалт эсвэл ашиглалтаас хэрэгжүүлэхээр хүлээгдэж буй эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхиас илүү өндөр дүнгээр тусгаж болохгүй гэсэн үзэл баримтлалтай нийцэх юм.
39. Бараа материалыг ихэвчлэн зүйл тус бүрээр нь цэвэр боломжит үнэ цэнэ хүртэл бууруулдаг. Гэвч зарим тохиолдолд ижил төсөөтэй буюу холбоотой зүйлсийг бүлэглэх нь тохиромжтой байж болно. Ижил төстэй зорилго буюу эцсийн хэрэглээтэй ба тухайн төрөл чиглэлийн бусад зүйлсээс тусдаа үнэлэх практик боломжгүй тохиолдолд ингэж бүлэглэж болох юм. Бэлэн бүтээгдэхүүн гэх мэт бараа материалын ангилалд эсвэл тухайн үйл ажиллагааны буюу газарзүйн сегмент дэх бүх бараа материалд үндэслэн бараа материалын үнэ цэнийг бууруулах нь тохиромжгүй байдаг. Үйлчилгээний байгууллага нь борлуулалтын тусдаа үнийг тогтоох үйлчилгээ нэг бүрийн хувьд өртгийг ерөнхийдөө хуримтлуулан тооцдог. Иймээс ийм үйлчилгээ нэг бүрийг тусдаа зүйл гэж үзнэ.

40. Цэвэр боломжит үнэ цэнийн тооцоололд мөн тухайн бараа материалыг эзэмшиж буй зорилгыг харгалзан үздэг. Жишээлбэл; хатуу тогтсон үнэтэй борлуулалтын буюу үйлчилгээний гэрээг биелүүлэх зорилгоор эзэмшиж буй бараа материалын тоо хэмжээний хувьд цэвэр боломжит үнэ цэнэ нь уг гэрээний үнэд үндэслэдэг. Хэрэв уг борлуулалтын гэрээнд хамаарах бараа материалын тоо хэмжээ нь эзэмшиж буй тухайн бараа материалын нийт тоо хэмжээнээс цөөн бол тэрхүү давсан тоо хэмжээний хувьд цэвэр боломжит үнэ цэнэ нь ердийн борлуулалтын үнэд үндэслэнэ. Эзэмшиж буй бараа материалын тоо хэмжээнээс давсан тоо хэмжээ бүхий хатуу тогтсон үнэтэй борлуулалтын гэрээний эсвэл хатуу тогтсон үнэтэй худалдан авалтын гэрээний улмаас нөөц буюу болзошгүй өр төлбөр тооцох талаархи заавар удирдамжийг УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-өөс үзэж болно.
41. Хэрэв материал ба бусад хангамжийн зүйлсийг ашиглан үйлдвэрлэх тухайн бэлэн бүтээгдэхүүнийг түүний өртгөөр эсвэл өртгөөс илүү дүнгээр борлуулах, арилжих буюу түгээн хуваарилахаар хүлээгдэж байгаа бол бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ашиглахаар эзэмшиж буй тэдгээр материал ба бусад хангамжийн зүйлсийг өртгөөс нь бага дүнгээр бууруулж бүртгэхгүй. Гэвч уг материалын үнийн бууралт нь тухайн бэлэн бүтээгдэхүүний өртөг өөрийн цэвэр боломжит үнэ цэнээс илүү давж гарсан гэдгийг илэрхийлэн харуулах тохиолдолд материалыг цэвэр боломжит үнэ цэнэ хүртэл бууруулан бүртгэнэ. Ийм тохиолдолд материалын орлуулалтын өртөг нь түүний цэвэр боломжит үнэ цэнийн талаархи бэлэн байгаа хамгийн сайн хэмжүүр болж болох юм.
42. Дараагийн тайлант үе бүрд цэвэр боломжит үнэ цэнийн талаархи шинэчилсэн үнэлгээг хийдэг. Бараа материалыг өмнө нь өртгөөс бага дүнгээр бууруулан бүртгэхэд хүргэсэн нөхцөл байдал цаашид оршин байхаа больсон эсвэл эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас цэвэр боломжит үнэ цэнэ өссөн талаархи тодорхой нотолгоо байгаа тохиолдолд өртөг ба уг өөрчлөн засварласан цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь шинэ дансны үнийг илэрхийлэхийн тулд тэрхүү бууруулан бүртгэсэн дүнг буцаадаг (өөрөөр хэлбэл, буцаалт нь анхны бууруулсан дүнгээр хязгаарлагдах юм). Тухайлбал; борлуулалтын үнэ нь буурсаны улмаас цэвэр боломжит үнэ цэнээр бүртгэсэн бараа материалын зүйл нь дараагийн тайлант үед гар дээр байсаар байгаа бөгөөд түүний борлуулалтын үнэ өссөн бол ийм тохиолдол үүснэ.

### **Барааг үнэгүй эсвэл нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилах**

43. Эдийн засгийн ирээдүйн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь цэвэр мөнгөн орлогын гүйлгээ бий болгох түүний чадвар, боломжтой шууд холбоогүй бараа материалыг улсын секторын байгууллага нь эзэмшдэг байж болно. Засгийн газар нь зарим барааг үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд ийм бараа материал үүсэж болох юм. Энэ тохиолдолд тухайн байгууллагын зорилтуудад хүрэхэд тэдгээр бараа материал шаардлагатай болвол түүний эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг олж авахын

тулд уг байгууллагын төлөх ёстой байсан дүнгээр тэрхүү бараа материалын эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг санхүүгийн тайлагналын зорилгоор тусгадаг. Уг эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг зах зээлээс олж авч чадахгүй тохиолдолд орлуулалтын өртгийг тооцоолох шаардлагатай байдаг. Бараа материалыг эзэмших зорилго өөрчлөгдсөн бол тэрхүү бараа материалыг 15-р параграфт заасан нөхцлүүдийн дагуу үнэлнэ.

### **Зардал гэж хүлээн зөвшөөрөх**

44. **Барааг борлуулах, сольж арилжих буюу түгээн хуваарилах тохиолдолд холбогдох орлогыг хүлээн зөвшөөрсөн тайлант үед тэдгээр бараа материалын дансны үнийг зардал гэж хүлээн зөвшөөрнө. Хэрэв хамаарах орлого байхгүй бол барааг түгээн хуваарилсан буюу холбогдох үйлчилгээг үзүүлсэн үед зардлыг хүлээн зөвшөөрнө. Бараа материалын аливаа бууруулалтын дүн ба бараа материалын бүх гарзыг тэдгээр бууруулалт эсвэл гарз гарсан тайлант үед зардал гэж хүлээн зөвшөөрнө. Бараа материалын аливаа бууруулалтыг буцаах аливаа буцаалтыг өмнө нь зардлаар хүлээн зөвшөөрсөн бараа материалын дүнгийн бууралт байдлаар тухайн буцаалт хийгдсэн тайлант үед хүлээн зөвшөөрнө.**
45. Үйлчилгээний байгууллагын хувьд, бараа материалыг зардал гэж хүлээн зөвшөөрөх хугацаа нь ихэвчлэн тухайн үйлчилгээг үзүүлсэн буюу төлбөртэй үйлчилгээний хувьд нэхэмжлэлийг гаргасан өдөр байна.
46. Зарим бараа материалыг, тухайлбал өөрөө барьж байгуулж буй үндсэн хөрөнгийн бүрэлдэхүүн хэсэг байдлаар ашиглагдах бараа материалыг бусад хөрөнгийн дансад хуваарилан ангилж болох юм. Ийм байдлаар өөр бусад хөрөнгөнд хуваарилагдсан бараа материалыг тухайн хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид зардал гэж хүлээн зөвшөөрнө.

### **Тодруулга**

47. **Санхүүгийн тайланд дараах зүйлсийг тодруулна:**
  - (a) **Бараа материалыг хэмжихэд баримталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, үүн дотроо ашигласан өртгийн томъёолол;**
  - (б) **Бараа материалын нийт дансны үнэ болон тухайн байгууллагад тохирох ангилал тус бүрийн бараа материалын дансны дүн;**
  - (в) **Борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээр бүртгэсэн бараа материалын дансны үнэ;**
  - (г) **Тухайн тайлант үед зардал гэж хүлээн зөвшөөрсөн бараа материалын дүн;**



- (д) **42-р параграфт заасны дагуу, тухайн тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрсөн бараа материалын аливаа бууруулалтын дүн;**
  - (е) **42-р параграфын дагуу тухайн тайлант үед санхүүгийн үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрсөн аливаа бууруулалтын буцаалтын дүн;**
  - (ж) **42-р параграфт заасны дагуу, бараа материалын бууруулалтын буцаалт хийхэд хүргэсэн нөхцөл байдал буюу үйл явдал;**
  - (и) **Өр төлбөрийн баталгаа болгож барьцаалсан бараа материалын дансны үнэ.**
48. Янз бүрийн ангилалд хамаарах бараа материалын дансны үнэ болон тэдгээр хөрөнгийн өөрчлөлтийн хэмжээний талаархи мэдээлэл нь санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ач холбогдолтой байдаг. Бараа материалын нийтлэг ангилал нь бараа, үйлдвэрлэлийн хангамжийн зүйлс, материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн юм. Үйлчилгээний байгууллагын бараа материалыг дуусаагүй үйлдвэрлэл гэж тодорхойлж болно.
49. Тайлант үеийн туршид зардлаар хүлээн зөвшөөрсөн бараа материалын дүн нь (а) одоо борлуулсан, сольж орлуулсан буюу түгээн хуваарилсан бараа материалын хэмжилтэнд өмнө нь багтаж байсан өртгүүд, ба (б) хуваарилагдаагүй үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал, бараа материалын үйлдвэрлэлийн хэвийн хэм хэмжээнээс давж хэтэрсэн өртөг зардлын дүнгээс бүрддэг. Тухайн байгууллагын онцлог нөхцөл байдал нь хуваарилалтын зардал гэх мэт бусад зардлуудыг мөн үүнд тусган оруулахыг зөвшөөрдөг байж болох юм.
50. Зарим байгууллагууд нь тухайн тайлант үеийн туршид зардал гэж хүлээн зөвшөөрсөн бараа материалын өртгөөс өөр байдлаар дүнгүүдийг толилуулах тийм ашиг, алдагдлын тайлангийн загварыг хэрэглэдэг. Ийм загварын дагуу байгууллага нь зардлын шинж төрөлд үндэслэсэн ангиллыг ашигласнаар зардлын задаргаа шинжилгээг толилуулна. Энэ тохиолдолд зардал гэж хүлээн зөвшөөрсөн тэрхүү өртгийг уг байгууллага нь (а) түүхий эд материал ба хангамжийн зүйлс, (б) хөдөлмөрийн зардал, (в) бусад зардал гэдгээр ангилж, тухайн тайлант үеийн бараа материалын үлдэгдлийн цэвэр өөрчлөлтийн хамтаар толилуулна.

## **Хүчин төгөлдөр болох хугацаа**

51. **Байгууллага нь энэхүү Стандартыг 2008 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2008 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.**

- 51А. УСНББОУС 27-гийн үр дүнд 29-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2011 оны 4 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Хэрэв байгууллага нь 2011 оны 4 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед УСНББОУС 27-г мөрдсөн бол уг нэмэлт өөрчлөлтийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.
- 51Б. 2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-ийн үр дүнд 52-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед УСНББОУС 33-ыг мөрдсөн бол уг нэмэлт өөрчлөлтийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.
- 51В. 2016 оны 4 дүгээр сард гаргасан УСНББОУС 2015-ын *Сайжруулалтууд*-аар 12-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 14А параграфыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 51Г. 2016 оны 4 дүгээр сард гаргасан УСНББОУС-ын *Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 4, 5-р параграфуудыг хассан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
52. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

## **УСНББОУС 12 (2001)-оос татгалзах**

53. Энэ Стандарт нь 2001 онд гаргасан УСНББОУС 12, *Бараа Материал*-ыг орлоно.

## Дүгнэлтийн Үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 12-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### Оршил

- ДҮ1. УСНББОУС3-ийн СТОУС-тай нийцүүлэх хөтөлбөр нь УСНББОУС3-ийн ажлын хөтөлбөрийн чухал элемент юм. УСНББОУС3-ийн бодлого нь улсын секторын байгууллагуудад тохиромжтой тохиолдолд НББОУС3-өөс гаргасан СТОУС-тай аккруэл суурьт УСНББОУС-ыг нийцүүлэх явдал юм.
- ДҮ2. Улсын секторын хувьд гажих тусгай учир шалтгаан байхаас бусад тохиолдолд СТОУС-тай нийцүүлсэн, аккруэл суурьт УСНББОУС нь СТОУС-ын шаардлага, бүтэц, текстийг тэр хэвээр хадгална. СТОУС-ын шаардлага буюу нэр томъёо нь улсын секторт тохиромжгүй эсвэл улсын секторын хувьд зарим тодорхой шаардлагуудыг үлгэрчлэн харуулахын тулд нэмэлт тайлбар буюу жишээ оруулах шаардлагатай тохиолдолд адилтгах СТОУС-аас гаждаг. УСНББОУС-ууд ба тэдгээртэй адилтгах СТОУС-уудын хоорондох ялгаатай талуудыг УСНББОУС нэг бүрд тусган оруулсан *СТОУС-тай Харьцуулалт*-д тодорхойлсон.
- ДҮ3. 2002 оны 5 дугаар сард өөрийн Ерөнхий Сайжруулалтын Төслийн нэг хэсэг болгон НББОУС3 нь 13-н НББОУС<sup>1</sup>-д оруулахаар санал болгосон нэмэлт өөрчлөлтийн саналын төслийг гаргасан. НББОУС3-ийн Ерөнхий Сайжруулалтын Төслийн зорилго нь “Стандартуудын хүрээн дэх сонголтод олон хувилбарууд, илүүдэл зүйлс, зөрчилтэй заалтуудыг арилгах буюу бууруулах, нийцүүлэлтийн зарим асуудлуудыг шийдэх ба бусад сайжруулалтыг хийх”-д оршино. НББОУС-ын эцсийн хувилбарыг 2003 оны 12 дугаар сард гаргасан.
- ДҮ4. 2001 оны 7 дугаар сард гаргасан УСНББОУС 12 нь НББОУС 2 (1993 онд хянан засварласан)-д үндэслэсэн. НББОУС 2-ыг 2003 оны 12 дугаар сард дахин гаргасан. УСНББОУС3-ийн өмнөх байгууллага болох Улсын Секторын Хороо (УСХ)<sup>2</sup> нь 2003 оны 12 дугаар сард гаргасан, сайжруулсан НББОУС-тай тохиромжтой хэмжээгээр УСНББОУС-ыг нийцүүлэхийн тулд УСНББОУС-ыг сайжруулах төслийг 2003 оны эцсээр хэрэгжүүлж эхэлсэн.
- ДҮ5. УСНББОУС3 нь уг сайжруулсан НББОУС 2-ыг нягталж шалгаад ингэж хянан засварлах болсон НББОУС3-ийн учир шалтгаан болон хийсэн

<sup>1</sup> НББОУС3-ийн өмнөх байгууллага болох НББОУСХ-ноос НББОУС-ыг гаргасан. НББОУС3-өөс гаргасан стандартуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) гэж нэрлэдэг. СТОУС-ыг НББОУС3 нь СТОУС, НББОУС, Стандартын Тайлбаруудаас бүрдэнэ гэж тодорхойлсон. Зарим тохиолдолд НББОУС3 нь НББОУС-ыг сольж орлуулахгүй, харин нэмэлт өөрчлөлт оруулдаг бөгөөд ингэснээр хуучин НББОУС-ын дугаарлалт хэвээр үлддэг.

<sup>2</sup> ДНБХ-ны Зөвлөл нь УСХ-г стандарт тогтоох бие даасан зөвлөл болгохын тулд түүний бүрэн эрхийг 2004 оны 11 дүгээр сард өөрчилснөөр УСХ нь УСНББОУС3 болсон.

нэмэлт өөрчлөлттэй ерөнхийдөө санал нэгдсэн. (НББОУСЗ-ийн Дүгнэлтийн Үндэслэлийг энд дахин нийтлээгүй болно. НББОУСЗ-ийн *Цогц Захиалгын Үйлчилгээ*-гээр захиалагч нар нь [www.iasb.org](http://www.iasb.org) хаягаар орж, НББОУСЗ-ийн вэб сайтаас Дүгнэлтийн Үндэслэлийг үзэж болно). УСНББОУС нь адилтгах НББОУС-аас гажих тохиолдолд улсын секторын хувьд гажих тусгай учир шалтгааныг Дүгнэлтийн Үндэслэлд тайлбарладаг.

ДҮ6. 2003 оны 12 дугаар сараас хойш гаргасан СТОУС-уудын үр дүнд НББОУС 2-д цаашид нэмэлт өөрчлөлт оруулсан. 2003 оны 12 дугаар сараас хойш гаргасан СТОУС-уудын үр дүн болох нэмэлт өөрчлөлтүүдийг УСНББОУС 12-д тусган оруулаагүй байна. Яагаад гэвэл, УСНББОУСЗ нь тэдгээр СТОУС-уудын шаардлагуудыг нягтлан шалгаж, улсын секторын байгууллагуудад мөрдөгдөх боломжит байдлын талаар өөрийн үзэл бодлыг хараахан илэрхийлээгүй байгаа юм.

#### **УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд-ын Хэсэг III-ын үр дүнд УСНББОУС 12-д хийсэн хянан засварлалт**

ДҮ7. Засгийн Газрын Санхүүгийн Статистик (ЗГСС)-ийн тайлагналын заавар нь нэг удаа ашиглах сум гэх мэт бүх зүйлсийг тусган илэрхийлэхийн тулд “цэргийн тоног төхөөрөмж” нэр томъёог ашигладаг. УСНББОУС-ын “сум” гэх мэт нэр томъёог ЗГСС-ын “цэргийн тоног төхөөрөмж” нэр томъёогоор орлуулах ба тайлбар тодорхойлолт оруулах нь ЗГСС-ын тайлагналын заавартай нийцтэй байдлыг нэмэгдүүлэхийн зэрэгцээгээр бараа материал гэж ангилах цэргийн хөрөнгийн төрлүүдийг илүү ойлгомжтой болгоно гэж УСНББОУСЗ дүгнэсэн.

#### **2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУСЗ-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 12-д хийсэн хянан засварлалт**

ДҮ8. УСНББОУСЗ нь 2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (a) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын зэрэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р* параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

## НББОУС 12-ТОЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 12, *Бараа Материал*-ыг НББОУС 2, *Бараа Материал* (2003 онд хянан засварласан)-аас үндсэндээ бэлтгэсэн болно. УСНББОУС 12 ба НББОУС 2-ын хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- УСНББОУС 12 нь НББОУС 2-оос өөр тодорхойлолтыг ашигладаг; ийм өөр тодорхойлолт нь улсын секторт зарим бараа материалыг үнэгүй эсвэл нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилна гэдгийг хүлээн зөвшөөрч, тусгадаг.
- Үйлчилгээг хүлээн авагчдаас хариуд нь төлбөр шууд авахгүй эсвэл нэрлэсэн төлбөр авснаар түгээн хуваарилах үйлчилгээний дуусаагүй үйлдвэрлэл нь энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй гэдгийг УСНББОУС 12-оор тодруулсан байдаг.
- НББОУС 2-д тусгасан тодорхойлолтуудаас гадна одоогийн орлуулалтын өртөг гэсэн тодорхойлолтыг УСНББОУС 12-д тусган оруулсан.
- Бараа материалыг арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн тохиолдолд тэдгээрийн өртгийг тухайн олж эзэмшсэн өдрөөрх бодит үнэ цэнээр хэмжихийг УСНББОУС 12-оор шаардсан байдаг.
- Бараа материалыг үнэгүй эсвэл нэрлэсэн төлбөртэйгээр нийлүүлдэг тохиолдолд тэдгээрийг өртөг ба одоогийн орлуулалтын өртгийн аль багаар үнэлэхийг УСНББОУС 12-оор шаардсан байдаг.
- УСНББОУС 12 нь зарим тохиолдолд НББОУС 2-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь УСНББОУС 12 дахь “санхүүгийн үр дүнгийн тайлан” гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. НББОУС 2 дахь адилтгах нэр томъёо нь “орлогын тайлан” юм.
- НББОУС 2-ийн хувьд “орлого” /revenue/ нэр томъёоноос илүү өргөн утгатай байдаг “орлого” /income/ нэр томъёог УСНББОУС 12-д ашигладаггүй.

## УСНББОУС 13–ТҮРЭЭС

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) 17, Түрээс (2003 онд хянан засварласан)-ээс үндсэндээ бэлтгэсэн болно. НББОУС 17-гоос авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон EC4M 6XH, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)

Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.

## УСНББОУС 13-ТҮРЭЭС

### УСНББОУС-ын түүх

Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

УСНББОУС 13, Түрээс-ийг 2001 оны 12 дугаар сард гаргасан.

2006 оны 12 дугаар сард УСНББОУС3 нь хянан засварласан УСНББОУС 13-ыг гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 13-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 32, Үйлчилгээний Концессын Хэлцэл: Эрх бүхий этгээд (2011 оны 10 дугаар сард гаргасан)
- УСНББОУС 2011-ийн Сайжруулалтууд (2011 оны 10 дугаар сард гаргасан)
- УСНББОУС 27, Хөдөө Аж Ахуй (2009 оны 12 дугаар сард гаргасан)
- УСНББОУС 31, Биет Бус Хөрөнгө (2010 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС-ын Сайжруулалтууд (2010 оны 11 дүгээр сард гаргасан)

### УСНББОУС 13-ын нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт

Өөрчлөгдсөн параграф	Хэрхэн өөрчилсөн	Юугаар өөрчилсөн
Танилцуулга хэсэг	Хассан	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
2	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 27, 2009 оны 12-р сар УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
3	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
4	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
19	Хассан	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
20	Хассан	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар

ТҮРЭЭС

20A	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
21	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
25	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 32, 2011 оны 10-р сар
26	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 32, 2011 оны 10-р сар
27	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 32, 2011 оны 10-р сар
36	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 31, 2010 оны 01-р сар
40	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
41	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 31, 2010 оны 01-р сар
44	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
66	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 31, 2010 оны 01-р сар
79	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
80	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
84A	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
85A	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
85Б	Шинэ	УСНББОУС 32, 2011 оны 10-р сар
85B	Шинэ	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
85Г	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
86	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар



## УСНББОУС 13–ТҮРЭЭС

## АГУУЛГА

	Параграф
Зорилго	1
Цар хүрээ	2-7
Тодорхойлолт	8-11
Түрээс үүссэн өдөр ба түрээсийн хугацааны эхлэлийн өдрийн хооронд түрээсийн төлбөрт гарсан өөрчлөлт	9
Хөлслөх худалдан авалтын гэрээ	10
Зээлийн өсөн нэмэгдэх хүүний түвшин	11
Түрээсийн ангилал	12-24
Түрээсийн болон бусад гэрээ	25-27
Түрээслэгчийн санхүүгийн тайлан дахь түрээс	28-44
Санхүүгийн түрээс	28-41
Үйл ажиллагааны түрээс	42-44
Түрээслүүлэгчийн санхүүгийн тайлан дахь түрээс	45-69
Санхүүгийн түрээс	45-61
Анхны хүлээн зөвшөөрөлт	50-61
Үйл ажиллагааны түрээс	62-69
Борлуулах ба буцаан түрээслэх ажил гүйлгээ	70-78
Шилжилтийн нөхцөл	79-84
Хүчин төгөлдөр болох хугацаа	85-86
УСНББОУС 13 (2001)-аас татгалзах	87
Дүгнэлтийн үндэслэл	
Хэрэгжүүлэх заавар удирдамж	
НББОУС 17-той харьцуулалт	

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 13, Түрээсийг 1-87-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 13-ыг түүний зорилгын агуулга, Дүгнэлтийн Үндэслэл, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

1. Энэ Стандартын зорилго нь санхүүгийн ба үйл ажиллагааны түрээстэй холбоотойгоор мөрдөх тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлого, тодруулгыг түрээслэгч болон түрээслүүлэгчийн хувьд тодорхойлоход оршино.

## Цар хүрээ

2. Нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар санхүүгийн тайлангаа бэлтгэн толилуулж буй байгууллага нь доор дурдсанаас бусад бүх түрээсийг тайлагнахдаа энэ Стандартыг мөрдөнө:

- (a) Ашигт малтмал, газрын тос, байгалийн хий болон эдгээртэй ижил төсөөтэй үл нөхөн сэргээгдэх баялгийн хайгуул хийх буюу ашиглах зориулалттай түрээс;
- (б) Кино хальс, дүрс бичлэг, урлагийн тоглолт, гар бичмэл, патент, зохиогчийн эрх гэх мэт зүйлсийн лицензийн гэрээ.

**Харин дараах зүйлсийн хэмжилтийн суурь болгон энэ Стандартыг мөрдөхгүй:**

- (a) Түрээслэгчийн эзэмшиж байгаа бөгөөд хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө (УСНББОУС 16, *Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө*-ийг үзнэ үү) гэж тайлагнадаг үл хөдлөх хөрөнгө;
- (б) Үйл ажиллагааны түрээсийн дагуу түрээслүүлэгчийн олгосон хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө (УСНББОУС 16-г үзнэ үү);
- (в) Түрээслэгчийн санхүүгийн түрээсийн дагуу эзэмшиж байгаа бөгөөд УСНББОУС 27, *Хөдөө Аж Ахуй*-н цар хүрээнд хамаарах биологийн хөрөнгө;
- (г) Үйл ажиллагааны түрээсийн дагуу түрээслүүлэгчийн олгосон бөгөөд УСНББОУС 27-гийн цар хүрээнд хамаарах биологийн хөрөнгө.

3. [Хассан]

4. [Хассан]

5. Хөрөнгийн үйл ажиллагаа буюу засвар үйлчилгээтэй холбоотойгоор түрээслүүлэгчийн мэдэгдэхүйц үйлчилгээг шаардаж болох боловч тухайн хөрөнгийн ашиглах эрхийг шилжүүлдэг хэлцэлд энэхүү Стандартыг мөрдөнө. Хөрөнгийн ашиглах эрхийг гэрээний нэг оролцогч талаас нөгөөд шилжүүлдэггүй үйлчилгээний гэрээ болох хэлцлийн хувьд энэ Стандартыг мөрдөхгүй. Улсын секторын байгууллагууд нь хөрөнгийн түрээсийг агуулдаг эсвэл агуулдаггүй байж болох үйлчилгээ үзүүлэх нарийн цогц

хэлцэл хийж болох юм. Ийм хэлцлүүдийг 25-27-р параграфт авч хэлэлцсэн.

6. Энэхүү Стандартыг (а) ашигт малтмал, газрын тос, байгалийн хий болон эдгээртэй ижил төсөөтэй үл нөхөн сэргээгдэх баялгийн хайгуул хийх буюу ашиглах зориулалттай түрээсийн гэрээнд болон (б) кино хальс, дүрс бичлэг, урлагийн тоглолт, гар бичмэл, патент, зохиогчийн эрх гэх мэт зүйлсийн лицензийн гэрээнд мөрдөхгүй. Яагаад гэвэл, ийм төрлийн гэрээнүүд нь тусдаа авч үзэх шаардлагатай нягтлан бодох бүртгэлийн цогц асуудлуудыг үүсгэх боломжтой байдаг.
7. Энэ Стандартыг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөнд мөрдөхгүй. Түрээслүүлэгч болон түрээслэгч нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг УСНББОУС 16-гийн нөхцлүүдийн дагуу хэмжинэ.

## Тодорхойлолт

8. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

Түрээсийн хугацааны эхлэлийн өдөр гэдэг нь тухайн түрээслэсэн хөрөнгөө ашиглах өөрийн эрхийг түрээслэгч хэрэгжүүлэх боломжтой болсон өдөр юм. Энэ нь түрээсийн анхны хүлээн зөвшөөрөлтийн (өөрөөр хэлбэл, түрээсээс үүсэх хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг тохиромжтой байдлаар хүлээн зөвшөөрөх) өдөр юм.

Болзошгүй түрээс гэдэг нь дүнгийн хувьд тогтмол боловч цаг хугацаа урсан өнгөрөлтөөс өөр бусад байдлаар өөрчлөгдөх хүчин зүйлийн ирээдүйн дүнд (жишээлбэл; ирээдүйн борлуулалтын хувийн жин, ирээдүйн ашиглалтын дүн, ирээдүйн үнийн индекс, хүүний зах зээлийн ирээдүйн хувь хэмжээ) үндэслэдэг түрээсийн төлбөрийн тэрхүү хэсэг юм.

Эдийн засгийн ашиглалтын хугацаа гэдэг нь дараах зүйлсийн аль нэг нь байна:

- (а) Нэг буюу хэд хэдэн хэрэглэгчдэд тухайн хөрөнгө нь эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бий болгохоор хүлээгдэж буй хугацаа; эсвэл
- (б) Нэг буюу хэд хэдэн хэрэглэгч нар нь тухайн хөрөнгөөс олж авахаар хүлээгдэж буй бүтээгдэхүүн буюу түүнтэй ижилт төсөөтэй нэгжүүдийн тоо хэмжээ.

Санхүүгийн түрээс гэдэг нь хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлдэг түрээс юм. Өмчлөлийн эрх нь аажмаар шилждэг эсвэл шилждэггүй байж болно.

Түрээсийн нийт хөрөнгө оруулалт гэдэг нь дараах зүйлсийн нийлбэр дүн байна:

- (a) Санхүүгийн түрээсийн дагуу түрээслүүлэгчийн авах түрээсийн хамгийн бага төлбөрүүд; ба
- (б) Түрээслүүлэгчид хуримтлагдах баталгаагүй, аливаа үлдэх өртөг.

**Баталгаатай үлдэх өртөг гэдэг нь:**

- (a) Түрээслэгчийн хувьд, тухайн түрээслэгч буюу уг түрээстэй холбоотой бусад талын баталгаа өгсөн үлдэх өртгийн тэрхүү хэсэг (баталгааны дүн нь аливаа тохиолдолд төлж болох хамгийн их дүн байна); ба
- (б) Түрээслүүлэгчийн хувьд, түрээслүүлэгчтэй холбоогүй бөгөөд уг баталгааны дагуу хүлээх үүргийг барагдуулах санхүүгийн чадвартай гуравдагч талаас эсвэл түрээслэгчээс баталгаа өгсөн үлдэх өртгийн тэрхүү хэсэг.

**Түрээс үүссэн өдөр** гэдэг нь түрээсийн гэрээний өдөр ба талууд уг түрээсийн үндсэн хугацаа, нөхцлийн хувьд хариуцлага хүлээсэн өдрийн аль эхэнд болох өдөр. Энэ өдрийн байдлаар:

- (a) Түрээсийг үйл ажиллагааны түрээс эсвэл санхүүгийн түрээс гэж ангилна; ба
- (б) Санхүүгийн түрээсийн хувьд, уг түрээсийн хугацааны эхлэлийн өдөр хүлээн зөвшөөрөх дүнг тодорхойлно.

**Анхны шууд зардал** гэдэг нь үйлдвэрлэгч буюу дилер түрээслүүлэгчийн гаргаснаас бусад, тухайн түрээсийн хэлцэл хийх ба зохион байгуулахтай шууд холбоотой өсөн нэмэгдсэн зардлууд юм.

**Түрээсийн нуугдмал хүүний түвшин** гэдэг нь түрээсийн үүссэн өдрөөрх (i) тухайн түрээслэсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ ба (ii) түрээслүүлэгчийн аливаа анхны шууд зардлын нийлбэрийг дараах зүйлсийн нийт өнөөгийн үнэ цэнэтэй тэнцүү болоход хүргэдэг дискаунтын хувь хэмжээ юм:

- (a) Түрээсийн хамгийн бага төлбөрүүд; ба
- (б) Баталгаагүй, үлдэх өртөг.

**Түрээс** гэдэг нь нэг төлбөр буюу цуврал төлбөрүүдийн хариуд түрээслүүлэгч нь тухайн хөрөнгийг тохиролцсон хугацаагаар ашиглах эрхийг түрээслэгчид шилжүүлдэг гэрээ юм.

**Түрээсийн хугацаа** гэдэг нь түрээслэгч тухайн хөрөнгийг түрээслэхээр гэрээ байгуулсан үл цуцлагдах хугацаа юм. Түрээслэгч нь хөрөнгийг үргэлжлүүлэн түрээслэх сонголтоо хэрэгжүүлнэ гэдэг нь уг түрээсийн хугацааны эхэнд үл үндэслэлтэйгээр тодорхой байх тохиолдолд нэмэлт төлбөр төлснөөр эсвэл төлөхгүйгээр

үргэлжлүүлэн түрээслэх түүний энэхүү сонголтонд хамаарах цаашдын аливаа хугацаа нь түрээсийн хугацаанд хамаарна.

Түрээслэгчийн зээлийн өсөн нэмэгдэх хүүний түвшин гэдэг нь ижил төсөөтэй хөрөнгийн хувьд түрээслэгчийн төлөх ёстой байсан хүүний хувь хэмжээ, хэрэв үүнийг тодорхойлох боломжгүй бол тухайн хөрөнгийг худалдан авахад шаардлагатай мөнгө, санг ижил төсөөтэй хугацаанд ба адилтгах баталгаатайгаар зээлдэн авахын тулд уг түрээслэгчийн төлөх байсан тэрхүү түрээсийн үүссэн өдрөөрх хүүний хувь хэмжээ юм.

Түрээсийн хамгийн бага төлбөрүүд гэдэг нь дараах зүйлсийн хамтаар үйлчилгээний өртөг болгон төлөхийг түрээслэгчээс шаарддаг буюу шаардаж болох тухайн түрээсийн хугацааны турш дахь төлбөрүүд юм. Үүнд болзошгүй түрээсийг оруулахгүй боловч тохиромжтой тохиолдолд түрээслүүлэгчийн төлсөн бөгөөд түүнд нөхөн олгох татварууд хамаарна.

- (a) Түрээслэгчийн хувьд, тухайн түрээслэгч эсвэл түрээстэй холбоотой бусад талын баталгаа гаргасан аливаа дүнгүүд; ба
- (б) Түрээслүүлэгчийн хувьд, түрээслүүлэгчид дараах талуудын зүгээс баталгаа өгсөн аливаа үлдэх өртөг:
  - (i) Түрээслэгч;
  - (ii) Түрээстэй холбоотой бусад тал; эсвэл
  - (iii) Түрээслүүлэгчтэй холбоогүй бөгөөд тухайн баталгааны дагуу хүлээх үүргийг барагдуулах санхүүгийн чадвартай, хараат бус гуравдагч этгээд.

Гэвч түрээслэгч нь сонголт хэрэгжих боломжтой болох өдрөөрх бодит үнэ цэнээс хангалттай бага байхаар хүлээгдэж буй тийм үнээр тухайн хөрөнгийг худалдан авах сонголттой бөгөөд сонголтыг хэрэгжүүлнэ гэдэг нь уг түрээс үүссэн өдөр ул үндэслэлтэйгээр тодорхой бол түрээсийн хамгийн бага төлбөрүүд нь энэхүү худалдан авалтын опционыг хэрэгжүүлэхээр хүлээгдэж буй өдөр хүртэлх түрээсийн хугацааны туршид төлөх хамгийн бага төлбөрүүд болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төлбөрөөс бүрдэнэ.

Түрээсийн цэвэр хөрөнгө оруулалт гэдэг нь түрээсийн нуугдмал хүүний түвшнээр дискаунтчилсан түрээсийн нийт хөрөнгө оруулалт юм.

Үл цуцлагдах түрээс гэдэг нь зөвхөн дараах тохиолдолд цуцалж болох түрээс юм:

- (a) Магадлал багатай зарим болзошгүй зүйлс гарч тохиолдсоноор;
- (б) Түрээслүүлэгчийн зөвшөөрснөөр;

- (в) Хэрэв түрээслэгч нь тухайн түрээслүүлэгчтэй уг хөрөнгө буюу адилтгах хөрөнгийн хувьд шинэ түрээсийн гэрээ байгуулсан бол; ба
- (г) Түрээс үүссэн өдрөөр ийм нэмэлт дүнг түрээслэгч төлснөөр тухайн түрээсийг үргэлжлүүлэх нь ул үндэслэлтэйгээр тодорхой болсон.

Үйл ажиллагааны түрээс гэдэг нь санхүүгийн түрээсээс бусад түрээс юм.

Урьдчилж орсон санхүүгийн орлого гэдэг нь дараах хоёр дүнгийн хоорондох зөрүү юм:

- (а) Түрээсийн нийт хөрөнгө оруулалт; ба
- (б) Түрээсийн цэвэр хөрөнгө оруулалт.

Баталгаагүй, үлдэх өртөг гэдэг нь уг үлдэх өртгийг олж авах эсэх талаар түрээслүүлэгчийн зүгээс баталгаа гаргаагүй эсвэл түрээслүүлэгчтэй холбоотой талаас зөвхөн баталгаа гаргасан тухайн түрээслэсэн хөрөнгийн үлдэх өртгийн тэрхүү хэсэг юм.

Ашиглалтын хугацаа гэдэг нь тухайн хөрөнгөнд агуулагдаж буй эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг түрээсийн хугацааны эхлэлийн өдрөөс уг байгууллага зарцуулахаар хүлээгдэж буй тооцоолсон үлдэх хугацаа бөгөөд үүнийг тэрхүү түрээсийн хугацаагаар хязгаарлахгүй.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь-д* дахин нийтэлсэн болно.

**Түрээс үүссэн өдөр ба түрээсийн хугацааны эхлэлийн өдрийн хооронд түрээсийн төлбөрт гарсан өөрчлөлт**

9. Түрээсийн гэрээ буюу түрээслэх баталгаа нь дараах зүйлсийн хувьд түрээсийн төлбөрийг залруулах нөхцөл, болзлуудыг агуулсан байж болно: (а) уг түрээслэсэн үл хөдлөх хөрөнгийг барьж байгуулах буюу худалдан авах өртөгт орсон өөрчлөлт, (б) үнийн ерөнхий түвшин гэх мэт өртөг буюу үнэ цэнийн бусад зарим хэмжилтийн өөрчлөлт, эсвэл түрээс үүссэн өдөр ба түрээсийн хугацааны эхлэлийн өдрийн хоорондох хугацаанд тухайн түрээсийг санхүүжүүлэх түрээслүүлэгчийн зардлын өөрчлөлт. Ингэж залруулах бол энэхүү Стандартын зорилгоор ийм аливаа өөрчлөлтийн үр нөлөөг тухайн түрээс үүссэн өдөр хийгдсэн гэж төсөөлнө.

#### **Хөлслөх худалдан авалтын гэрээ**

10. Тохиролцсон нөхцлүүд биелснээр тухайн хөрөнгийн өмчлөх эрхийг олж авах сонголтыг уг хөлслөгчид олгох нөхцөл заалт бүхий хөрөнгө хөлслөх гэрээ нь түрээсийн тодорхойлолтонд хамаарна.

### **Зээлийн өсөн нэмэгдэх хүүний түвшин**

11. Байгууллага нь засгийн газраас баталгаа гаргасан зээлтэй тохиолдолд түрээслэгчийн зээлийн өсөн нэмэгдэх хүүний түвшний тодорхойлолт нь засгийн газрын аливаа баталгаа болон түүний холбогдох хураамжийг тусгасан байна. Энэ нь зээлийн арай бага өсөн нэмэгдэх хүүний түвшин ашиглахад ихэвчлэн хүргэдэг.

### **Түрээсийн ангилал**

12. Энэхүү Стандартад заасан түрээсийн ангилал нь уг түрээслэсэн хөрөнгийн өмчлөлтэй холбоотой эрсдэл ба урамшуулал нь түрээслүүлэгчид эсвэл түрээслэгчид хамаарах хэмжээнд үндэслэдэг. Эрсдэл нь (а) сул зогсолт, технологийн хоцрогдлоос үүсэх алдагдал, (б) эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлтийн улмаас үнэ цэнэ хувьсан өөрчлөгдөх боломжит байдлуудыг агуулсан байдаг. Урамшууллыг тухайн хөрөнгийн эдийн засгийн ашиглалтын хугацаан дахь үйлчилгээний чадавхи буюу ашигт ажиллагааны хүлээлт, үнэ цэнийн өсөлт эсвэл үлдэх өртгийн хэрэгжүүлэлтээс үүсэх олзоор илэрхийлж болох юм.
13. **Түрээс нь тухайн хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлдэг бол түүнийг санхүүгийн түрээс гэж ангилна. Хэрэв түрээс нь хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлдэггүй бол түүнийг үйл ажиллагааны түрээс гэж ангилна.**
14. Түрээслүүлэгч ба түрээслэгчийн хоорондох ажил гүйлгээ нь тэдгээрийн хооронд хийгдсэн түрээсийн гэрээнд үндэслэдэг учраас тууштай тодорхойлолтуудыг ашиглах нь тохиромжтой юм. Түрээслүүлэгч ба түрээслэгчийн янз бүрийн нөхцөл байдал дахь тэдгээр тодорхойлолтын хэрэглээ нь нэг түрээсийг тэд өөр өөр байдлаар ангилахад хүргэж болох билээ. Жишээлбэл; түрээслүүлэгч нь уг түрээстэй холбоогүй талын гаргасан үлдэх өртгийн баталгаанаас үр өгөөж хүртдэг бол ийм нөхцөл байдал үүсэж болох юм.
15. Санхүүгийн түрээс эсвэл үйл ажиллагааны түрээс болох эсэх нь тухайн гэрээний хэлбэрээс бус, харин ажил гүйлгээний мөн чанараас хамаардаг. Бие даасан буюу нэгдсэн байдлаараа тухайн түрээсийг санхүүгийн түрээс гэж ангилахад ихэвчлэн хүргэдэг нөхцөл байдлуудын жишээнд дараах зүйлс хамаарах боловч санхүүгийн түрээс гэж ангилагдахын тулд түрээс нь эдгээр бүх шалгуурыг заавал хангах албагүй байдаг:
  - (а) Түрээс нь тухайн хөрөнгийн өмчлөлийг түрээсийн хугацааны эцэст түрээслэгчид шилжүүлдэг;
  - (б) Түрээслэгч нь сонголт хэрэгжих боломжтой болох өдрөөрх бодит үнэ цэнээс хангалттай бага байхаар хүлээгдэж буй тийм үнээр уг хөрөнгийг худалдан авах сонголттой бөгөөд сонголтыг хэрэгжүүлнэ гэдэг нь тухайн түрээс үүссэн өдөр ул үндэслэлтэйгээр тодорхой байх;



- (в) Хэдийгээр эрхийг шилжүүлээгүй боловч түрээсийн хугацаа нь тухайн хөрөнгийн эдийн засгийн ашиглалтын хугацааны гол хэсгийг бүрдүүлдэг байх;
  - (г) Түрээс үүссэн өдрөөрх уг түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнэ нь тухайн түрээслэсэн хөрөнгийн бодит үнэ цэнэтэй хамгийн наад зах нь бараг тэнцүү байх;
  - (д) Тухайн хөрөнгө нь зөвхөн уг түрээслэгч томоохон засвар өөрчлөлт хийхгүйгээр ашиглаж болох тийм тусгайлсан шинж чанартай байх.
  - (е) Тухайн түрээслэсэн хөрөнгийг өөр хөрөнгөөр хялбархан орлуулах боломжгүй байх.
16. Бие даасан буюу нэгдсэн байдлаараа түрээсийг санхүүгийн түрээс гэж ангилахад хүргэж болох бусад шинж тэмдэгт дараах зүйлс хамаарна:
- (а) Хэрэв түрээслэгч нь түрээсийг цуцалвал уг цуцлалттай холбоотойгоор түрээслүүлэгчид учрах алдагдлыг тухайн түрээслэгч хариуцдаг байх;
  - (б) Үлдэх хэсгийн бодит үнэ цэнийн хэлбэлзлээс үүсэх олз, гарз нь түрээслэгчид хуримтлагдан хамаардаг байх (жишээлбэл; түрээсийн төлбөрт хөнгөлөлт үзүүлэх замаар үлдэх хэсгийн бодит үнэ цэнийг тухайн түрээсийн хугацааны эцэс дэх борлуулалтын орлогын ихэнх хэсэгтэй тэнцүүлэх);
  - (в) Түрээслэгч нь зах зээлийн түрээсийн түвшнээс мэдэгдэхүйц бага дүнгээр уг түрээсийг хоёр дахь хугацаанд үргэлжлүүлэн түрээслэх боломжтой байх.
17. 15 ба 16-р параграфт дурдсан, жишээ болон шинж тэмдгүүд нь эцсийн дүгнэлтийн шинжтэй байдаггүй. Хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бараг бүх эрсдэл ба өгөөжийг уг түрээсээр шилжүүлдэггүй гэдэг нь бусад шинж чанаруудаас ойлгомжтой бол тухайн түрээсийг үйл ажиллагааны түрээс гэж ангилна. Жишээлбэл; (а) түрээсийн хугацааны эцэст хөрөнгийн өмчлөлийг уг өдрөөрх түүний бодит үнэ цэнэтэй тэнцүү, тийм хувьсах төлбөрөөр шилжүүлдэг, эсвэл (б) түрээслэгч нь бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлдэггүй учраас болзошгүй түрээстэй байдаг бол ийм тохиолдол үүсэж болох юм.
18. Түрээсийн ангиллыг түүний үүссэн өдөр хийнэ. Түрээсийг дахин шинэчлэхээс бусад, түрээсийн өөрчлөгдсөн нөхцөл заалт нь уг түрээс үүссэн өдөр хэрэв хүчин төгөлдөр байсан бол 12-17-р параграфт заасан шалгуурын дагуу түрээсийг өөрөөр ангилахад хүргэхүйц тийм байдлаар, түрээслэгч ба түрээслүүлэгч нь тухайн түрээсийн нөхцөл заалтуудыг өөрчлөхөөр тохиролцсон тохиолдолд уг хянан засварласан түрээсийн гэрээг түүний хугацааны туршид шинэ гэрээ гэж үзнэ. Харин тооцооллын өөрчлөлт (жишээлбэл; уг түрээслэсэн үл хөдлөх хөрөнгийн эдийн засгийн ашиглалтын хугацаа буюу үлдэх өртгийн тооцооллын өөрчлөлт) эсвэл нөхцөл байдлын өөрчлөлт (жишээлбэл; түрээслэгч нь төлбөрөө төлөхгүй

байх) нь нягтлан бодох бүртгэлийн зорилгын хувьд түрээсийг шинээр ангилахад хүргэхгүй.

19. [Хассан]

20. [Хассан]

20А. Түрээс нь газар ба барилга гэсэн элементийн аль алиныг агуулдаг тохиолдолд 12-18-р параграфыг мөрдсөнөөр байгууллага нь эдгээр элемент нэг бүрийн санхүүгийн түрээс эсвэл үйл ажиллагааны түрээс гэсэн ангиллыг тус тусад нь үнэлнэ. Газар гэсэн элемент нь үйл ажиллагааны түрээс эсвэл санхүүгийн түрээс эсэхийг тодорхойлохдоо гол анхаарах зүйл нь газар ихэвчлэн тодорхой бус ашиглалтын хугацаатай байдаг явдал юм.

21. Газар ба барилгын түрээсийг ангилж, тайлагнах шаардлагатай болсон аливаа тохиолдолд түрээс үүссэн өдрөөрх уг түрээсийн газрын болон барилгын элементүүд дэх түрээсийн эзэмшилтийн хувь оролцооны харгалзах бодит үнэ цэнэтэй хувь тэнцүүлэх замаар тэдгээр түрээсийн хамгийн бага төлбөрүүдийг (үүн дотроо, бөөн дүнгээр хийх аливаа шууд төлбөрүүдийг) газар ба барилгын элементүүдэд хуваарилна. Хэрэв түрээсийн төлбөрийг энэхүү хоёр элементэд найдвартайгаар<sup>1</sup> хуваарилж чадахгүй бол эдгээр элемент хоёулаа үйл ажиллагааны түрээс гэдэг нь тодорхой байхаас бусад тохиолдолд тухайн нийт түрээсийг санхүүгийн түрээс гэж ангилна. Харин эдгээр элемент хоёулаа үйл ажиллагааны түрээс гэдэг нь тодорхой бол тухайн нийт түрээсийг үйл ажиллагааны түрээс гэж ангилна.

22. 28-р параграфын дагуу газар гэсэн элементэд эхлээд хүлээн зөвшөөрөх дүн нь материаллаг бус байх газар ба барилгын түрээсийн хувьд, тэрхүү газар болон барилгыг түрээсийн ангиллын зорилгоор нэг нэгж гэж үзэх бөгөөд 12-18-р параграфыг мөрдсөнөөр түүнийг санхүүгийн түрээс эсвэл үйл ажиллагааны түрээс гэж ангилж болох юм. Энэ тохиолдолд барилгын эдийн засгийн ашиглалтын хугацааг тухайн түрээслэсэн нийт хөрөнгийн эдийн засгийн ашиглалтын хугацаагаар авч үзнэ.

23. Газар ба барилгын аль алин дахь түрээслэгчийн хувь оролцоог УСНББОУС 16-гийн дагуу хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэж ангилдаг бөгөөд бодит үнэ цэнийн загвар ашигладаг тохиолдолд тухайн газар ба барилгын элементүүдийн тусдаа хэмжилт хийх шаардлагагүй юм.

24. Түрээслэгч нь үйл ажиллагааны түрээсээр эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийн хувь оролцоогоо УСНББОУС 16-гийн дагуу хөрөнгө оруулалтын

---

<sup>1</sup> Найдвартай мэдээлэл нь материаллаг алдаа ба туйлшралаас ангид байх бөгөөд өөрийн илэрхийлэхээр зориулагдсан буюу илэрхийлнэ гэж үл үндэслэлтэйгээр хүлээж болох зүйлсийг үнэн зөв илэрхийлэхдээ хэрэглэгчдээс хамаардаг байж болох юм. Найдвартай байдлын тайлбарын талаархи шилжилтийн арга хандлагыг УСНББОУС 1-ийн ДҮ16-р параграфт авч хэлэлцсэн.

зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэж ангилах боломжтой байдаг. Хэрэв ингэж ангилсан бол уг үл хөдлөх хөрөнгийн хувь оролцоог санхүүгийн түрээс байсан мэтээр тайлагнах бөгөөд тухайн хүлээн зөвшөөрсөн хөрөнгийн хувьд бодит үнэ цэнийн загварыг ашиглана. Дараагийн тайлант үеийн үйл явдал нь түүнийг цаашид хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэж ангилах боломжгүй болгох байдлаар тухайн түрээслэгчийн үл хөдлөх хөрөнгийн хувь оролцооны шинж төрлийг өөрчилсөн байлаа ч гэсэн түрээслэгч нь уг түрээсийг санхүүгийн түрээс гэж тайлагнасан хэвээр байна. Дараах тохиолдолд ингэж тайлагнасан хэвээр байдаг. Жишээлбэл; түрээслэгч нь:

- (а) ашиглалт өөрчлөгдсөн өдрөөрх түүний бодит үнэ цэнэтэй тэнцүү байх төсөөлөн тооцсон өртгөөр эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгөнд дараа нь шилжүүлэх тийм үл хөдлөх хөрөнгийг эзэмшдэг; эсвэл
- (б) тухайн хувь оролцоотой холбоотой бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлэх дамжуулан түрээсийн эрхийг харилцан хамааралгүй гуравдагч этгээдэд олгодог. Ийм түрээсийг уг гуравдагч этгээд нь үйл ажиллагааны түрээс гэж тайлагнаж болох боловч түрээслэгч нь тэрхүү гуравдагч талд олгосон санхүүгийн түрээс байдлаар тайлагнана.

## Түрээсийн болон бусад гэрээ

- 25. Гэрээ нь хөрөнгө түрээслэх гэрээнээс зөвхөн бүрддэг байж болох юм. Мөн түүнчлэн, түрээс нь хөрөнгийг барьж байгуулах, өмчлөх, ажиллуулах болон шилжүүлэхийн тулд хувийн хэвшлийн байгууллагуудтай байгуулсан өргөн хүрээтэй цогц гэрээний нэг элемент байж болно. Улсын секторын байгууллагууд нь ялангуяа урт хугацаат биет хөрөнгө болон дэд бүтцийн хөрөнгөтэй холбоотойгоор ийм хэлцлийг байнга хийдэг. Өөр бусад хэлцэл нь хувийн хэвшлээс дэд бүтцийг түрээслэж буй улсын секторын байгууллагатай хамааралтай байж болно. Тухайн хэлцэл нь УСНББОУС 32, *Үйлчилгээний Концессын Хэлцэл: Эрх бүхий этгээд*-д тодорхойлсон үйлчилгээний концессын хэлцэл мөн эсэхийг уг байгууллага тодорхойлно.
- 26. Хэлцэл нь УСНББОУС 32-д заасан, үйлчилгээний концессын хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийн нөхцлүүдийг хангахгүй бөгөөд энэхүү Стандартад тодорхойлсон ялган тодорхойлж болох үйл ажиллагааны түрээс эсвэл санхүүгийн түрээсийг агуулдаг тохиолдолд уг хэлцлийн түрээсийн бүрэлдэхүүн хэсгийг тайлагнахдаа энэ Стандартын нөхцлүүдийг мөрдөнө.
- 27. Улсын секторын байгууллагууд нь зориулагдсан хөрөнгүүдийн ашиглалтыг зайлшгүй агуулах бараа ба/буюу үйлчилгээг нийлүүлэх янз бүрийн хэлцлүүдийг мөн байгуулж болно. Ийм зарим хэлцэл нь УСНББОУС 32-д тодорхойлсон үйлчилгээний концессын хэлцэл эсвэл энэ Стандартад тодорхойлсон түрээс эсэх нь тодорхой бус байх асуудал үүсэж болох юм. Ийм тохиолдолд мэргэжлийн шүүн тунгаалт хийх ба хэрэв түрээс бол энэ Стандартыг мөрдөнө; харин түрээс биш бол байгууллага нь бусад холбогдох УСНББОУС-ын заалтуудыг мөрдөнө, ийм

заалтууд байхгүй бол бусад холбогдох олон улсын болон үндэсний нягтлан бодох бүртгэлийн стандартын заалтуудыг мөрдсөнөөр уг хэлцлийг тайлагнана.

## Түрээслэгчийн санхүүгийн тайлан дахь түрээс

### Санхүүгийн түрээс

28. Түрээсийн хугацааны эхлэлийн өдөр түрээслэгч нь санхүүгийн түрээсээр олж эзэмшсэн хөрөнгийг өөрийн санхүүгийн байдлын тайландаа хөрөнгө гэж, холбогдох түрээсийн өглөгийг өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө. Хөрөнгө, өр төлбөрийг уг түрээслэсэн үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнэ эсвэл тухайн түрээс үүссэн өдрөөр тодорхойлсон, түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийн аль багатай тэнцүү байх дүнгээр хүлээн зөвшөөрдөг. Түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийг тооцоолоход ашиглах дискаунтын хувь хэмжээ нь хэрэв тодорхойлох практик боломжтой бол түрээсийн нуугдмал хүүний түвшин байна, харин тодорхойлох практик боломжгүй бол түрээслэгчийн зээлийн өсөн нэмэгдэх хүүний түвшинг ашиглана.
29. Ажил гүйлгээ ба бусад үйл явдлуудыг зөвхөн хуулийн хэлбэрийн дагуу биш, харин тэдгээрийн мөн чанар ба санхүүгийн бодит байдалд нийцүүлэн тайлагнаж, толилуулна. Хэдийгээр түрээсийн гэрээний хуулийн хэлбэрийн дагуу түрээслэгч нь уг түрээслэсэн хөрөнгийн хууль ёсны өмчлөх эрхийг олж аваагүй байж болох боловч санхүүгийн түрээсийн хувьд түрээслэгч нь тэрхүү түрээслэсэн хөрөнгийг түүний эдийн засгийн ашиглалтын хугацааны ихэнх хэсэгт ашигласнаар бий болох эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг олж эзэмших, ийм эрхийнхээ хариуд, түрээс үүссэн өдрөөрх тухайн хөрөнгийн бодит үнэ цэнэ болон холбогдох санхүүгийн зардалтай ойролцоогоор тэнцүү дүнг төлөх үүргийг хүлээх тийм мөн чанар ба санхүүгийн бодит байдалтай байдаг.
30. Ийм түрээсийн ажил гүйлгээг тухайн түрээслэгчийн санхүүгийн байдлын тайланд тусгахгүй бол түүний хөрөнгө, өр төлбөрийг дутуу илэрхийлж, ингэснээр санхүүгийн харьцааг гажуудуулахад хүргэнэ. Иймээс санхүүгийн түрээсийг тухайн түрээслэгчийн санхүүгийн тайланд хөрөнгө, түүнчлэн ирээдүйн түрээсийн төлбөрүүдийг төлөх үүргийн аль алианаар хүлээн зөвшөөрөх нь зохистой юм. Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн дүн дээр нэмэгдэх тухайн түрээслэгчийн аливаа анхны шууд зардлаас бусад, хөрөнгө, түүнчлэн ирээдүйн түрээсийн төлбөрүүдийг төлөх өр төлбөрийг тухайн түрээс үүссэн өдрөөр санхүүгийн тайланд нэг ижил дүнгээр хүлээн зөвшөөрнө.
31. Түрээслэсэн хөрөнгөнд хамаарах өр төлбөрийг санхүүгийн тайланд тухайн түрээслэсэн хөрөнгөөс хасагдах дүн байдлаар толилуулах нь тохиромжгүй юм.

32. Санхүүгийн байдлын тайланд өр төлбөрийг толилуулахдаа богино ба урт хугацаат өр төлбөр гэдгээр ялгагдаг бол түрээсийн өр төлбөрийг мөн ингэж ялган толилуулна.
33. Түрээсийн гэрээний хэлцэл хийх, баталгаажуулах гэх мэт түрээсийн тодорхой үйл ажиллагаатай холбоотойгоор анхны шууд зардал ихэвчлэн гардаг. Санхүүгийн түрээсийн хувьд түрээслэгчийн гүйцэтгэх үйл ажиллагаанд шууд хамааруулж болно гэж тодорхойлсон ийм өртөг зардлыг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн дүн дээр нэмнэ.
34. **Түрээсийн хамгийн бага төлбөрүүдийг санхүүгийн зардал ба төлөгдөөгүй өр төлбөрийн бууралтад төсөвлөн хуваарилна. Өр төлбөрийн үлдсэн дүнгээс хүүг тогтмол үечилсэн хувь хэмжээгээр тооцохын тулд санхүүгийн зардлыг тухайн түрээсийн хугацааны туршид тайлант үе бүрд хуваарилна. Болзошгүй түрээсийг түүний гарсан тайлант үед зардал байдлаар шингээн тусгана.**
35. Практикт, санхүүгийн зардлыг тухайн түрээсийн хугацааны туршид тайлант үеүдэд шингээн хуваарилахдаа түрээслэгч нь тооцооллыг хялбарчлахын тулд зарим ойролцоо тооцооллын хэлбэрийг ашиглаж болно.
36. **Санхүүгийн түрээс нь элэгдэх хөрөнгийн хувьд тайлант үе тус бүрд элэгдлийн зардал, түүнчлэн санхүүгийн зардал үүсэхэд хүргэдэг. Түрээслэсэн, элэгдэх хөрөнгийн элэгдлийн бодлого нь өмчилж буй, адилтгах элэгдэх хөрөнгийн элэгдлийн бодлоготой нийцсэн байх бөгөөд тухайн хүлээн зөвшөөрөх элэгдлийн зардлыг УСНББОУС 17, Үндсэн Хөрөнгө ба УСНББОУС 31, Биет Бус Хөрөнгө-ийн аль тохиромжтой стандартын дагуу тооцоолно. Хэрэв түрээслэгч нь түрээсийн хугацааны эцэст тухайн хөрөнгийн өмчлөлийг олж авах эсэх нь ул үндэслэлтэйгээр тодорхой биш бол тэрхүү хөрөнгийг түрээсийн хугацаа эсвэл түүний ашиглалтын хугацааны аль богинод бүрэн элэгдүүлнэ.**
37. Түрээслэсэн хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний хүлээгдэж буй ашиглалтын хугацааны туршид системтэй сууриар тайлант үе нэг бүрд хуваарилна. Энэхүү системтэй суурь нь өмчилж буй, элэгдэх хөрөнгийн хувьд түрээслэгчийн мөрддөг элэгдлийн бодлоготой нийцсэн байна. Түрээслэгч нь түрээсийн хугацааны эцэст тухайн хөрөнгийн өмчлөлийг хүлээж авна гэдэг нь ул үндэслэлтэйгээр тодорхой бол хүлээгдэж буй ашиглалтын хугацаа нь уг хөрөнгийн ашиглалтын хугацаа байна. Харин ийм тодорхой биш бол тухайн хөрөнгийг түрээсийн хугацаа буюу түүний ашиглалтын хугацааны аль богинод элэгдүүлнэ.
38. Хөрөнгийн тухайн тайлант үеийн элэгдлийн зардал ба санхүүгийн зардлын нийлбэр нь тэрхүү тайлант үед төлөх түрээсийн төлбөрүүдтэй байнга тэнцүү байдаггүй тул түрээсийн өглөгийг шууд зардал гэж хүлээн зөвшөөрөх нь тохиромжгүй юм. Иймээс тухайн хөрөнгө ба холбогдох өр

төлбөр нь түрээсийн хугацааны эхлэлийн өдрөөс хойш тэнцүү дүнтэй байх магадлал багатай юм.

39. Түрээслэсэн хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэхийг тодорхойлохын тулд байгууллага нь УСНББОУС 21, *Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт* ба УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-д заасан, холбогдох үнэ цэнийн бууралтын сорилыг хийнэ.
40. **Түрээслэгч нь санхүүгийн түрээсийн хувьд дараах зүйлсийг тодруулна:**
- (a) **Хөрөнгийн анги тус бүрийн хувьд тухайн тайлангийн өдрөөрх цэвэр дансны үнэ;**
  - (b) **Тухайн тайлангийн өдрийн байдлаарх ирээдүйн түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн нийт дүн ба тэдгээрийн өнөөгийн үнэ цэнийн хоорондох тохируулгын тайлан;**
  - (в) **Түүнчлэн, байгууллага нь тухайн тайлангийн өдрийн байдлаарх ирээдүйн түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн нийт дүн ба тэдгээрийн өнөөгийн үнэ цэнийг дараах тайлант үе тус бүрээр тодруулна:**
    - (i) **Нэг жилээс илүүгүй;**
    - (ii) **Нэг жилээс илүү боловч таван жилээс илүүгүй; ба**
    - (iii) **Таван жилээс илүү;**
  - (г) **Тухайн тайлант үед зардал гэж хүлээн зөвшөөрсөн болзошгүй түрээс;**
  - (д) **Үл цуцлагдах дамжуулан түрээсийн дагуу хүлээн авахаар тухайн тайлангийн өдрийн байдлаар хүлээгдэж буй ирээдүйн дамжуулан түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн нийт дүн; ба**
  - (e) **Түрээслэгчийн материаллаг дүн бүхий түрээсийн хэлцлүүдийн ерөнхий тайлбар тодорхойлолт, үүнд дараах зүйлс багтах боловч үүгээр хязгаарлагдахгүй:**
    - (i) **Болзошгүй түрээсийн өглөгийг тодорхойлох суурь;**
    - (ii) **Түрээсийг сунгах эсвэл түрээсийн хөрөнгийг худалдан авах сонголт болон өргөжүүлэх заалт байгаа эсэх болон түүний нөхцлүүд; ба**
    - (iii) **Ашгийн буцаалт, капиталын хувь оролцооны буцаалт, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт, нэмэлт өр, цаашдын түрээслэлт гэх мэт асуудлуудын талаархи түрээсийн гэрээгээр тогтоосон хязгаарлалтууд.**
41. Түүнчлэн, УСНББОУС 16, УСНББОУС 17, УСНББОУС 21, *Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*, УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*, УСНББОУС 31-д нийцүүлэн

тухайн байгууллагын мөрддөг тодруулгын шаардлагуудыг хөрөнгийн худалдан авалт байдлаар түрээслэгчийн тайлагнадаг санхүүгийн түрээсийн дагуу түрээслэсэн хөрөнгүүдэд мөрдөнө.

### Үйл ажиллагааны түрээс

42. Системтэй өөр суурь нь хэрэглэгчийн өгөөжийн цаг хугацааны хэв загварыг төлөөлөн илэрхийлэхээс бусад тохиолдолд үйл ажиллагааны түрээсийн дагуу төлөх түрээсийн төлбөрүүдийг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын сууриар зардал гэж хүлээн зөвшөөрнө.
43. Системтэй өөр суурь нь хэрэглэгчийн өгөөжийн цаг хугацааны хэв загварыг төлөөлөн илэрхийлэхээс бусад тохиолдолд үйл ажиллагааны түрээсийн хувьд хэдийгээр түрээсийн төлбөрийг шулуун шугамын сууриар төлдөггүй ч гэсэн түрээсийн төлбөрүүдийг (даатгал, засвар үйлчилгээ гэх мэт үйлчилгээний зардал хамаарахгүй) шулуун шугамын сууриар зардал гэж хүлээн зөвшөөрнө.
44. Түрээслэгч нь үйл ажиллагааны түрээсийн хувьд дараах зүйлсийг тодруулна:
- (а) Дараах тайлант үе тус бүрийн хувь үл цуцлагдах үйл ажиллагааны түрээсийн дагуу төлөх ирээдүйн түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн нийт дүн:
    - (i) Нэг жилээс илүүгүй;
    - (ii) Нэг жилээс илүү боловч таван жилээс илүүгүй; ба
    - (iii) Таван жилээс илүү;
  - (б) Үл цуцлагдах дамжуулан түрээсийн дагуу хүлээн авахаар тухайн тайлангийн өдрийн байдлаар хүлээгдэж буй ирээдүйн дамжуулан түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн нийт дүн;
  - (в) Тайлант үед зардал гэж хүлээн зөвшөөрсөн түрээсийн болон дамжуулан түрээсийн төлбөрүүдийг тухайн түрээсийн хамгийн бага төлбөрүүд, болзошгүй түрээс, дамжуулан түрээсийн төлбөрүүдийн хамт; ба
  - (г) Түрээслэгчийн материаллаг дүн бүхий түрээсийн хэлцлүүдийн ерөнхий тайлбар тодорхойлолт, үүнд дараах зүйлс багтах боловч үүгээр хязгаарлагдахгүй:
    - (i) Болзошгүй түрээсийн төлбөрийг тодорхойлох суурь;
    - (ii) Түрээсийг сунгах эсвэл түрээсийн хөрөнгийг худалдан авах сонголт болон өргөжүүлэх заалт байгаа эсэх болон түүний нөхцлүүд; ба
    - (iii) Ашгийн буцаалт, капиталын хувь оролцооны буцаалт, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт, нэмэлт өр,

**цаашдын түрээслэлт гэх мэт асуудлуудын талаархи түрээсийн гэрээгээр тогтоосон хязгаарлалтууд.**

**Түрээслүүлэгчийн санхүүгийн тайлан дахь түрээс**

**Санхүүгийн түрээс**

45. Энэ Стандарт нь санхүүгийн түрээсийн дагуу олох санхүүгийн орлогын нягтлан болох бүртгэлийн хандлагыг тодорхойлдог. Хөрөнгийг үйлдвэрлэх буюу худалдан арилждаг бөгөөд өөрсдийн түрээсийн, худалдаа арилжааны болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааны цар хэмжээнээс үл хамааран тэдгээр хөрөнгийн түрээслүүлэгчийн үүргийг бас гүйцэтгэдэг улсын секторын бүх байгууллагуудыг илэрхийлэхийн тулд энэ Стандартад “үйлдвэрлэгч буюу дилер түрээслүүлэгч” гэсэн нэр томъёог ашигладаг. Үйлдвэрлэгч буюу дилер түрээслүүлэгч байгууллагын хувьд хөрөнгийн шилжүүлгээс үүсэх олз, гарзын нягтлан бодох бүртгэлийн хандлагыг мөн энэ Стандартад тодорхойлсон.
46. Улсын секторын байгууллагууд нь янз бүрийн нөхцөл байдалд түрээслүүлэгч байдлаар оролцох санхүүгийн түрээсийн гэрээ байгуулж болох юм. Улсын секторын зарим байгууллагууд нь ердийн сууриар хөрөнгийг арилжиж болно. Тухайлбал; засгийн газар нь бусад бүх байгууллагуудын хөрөнгийн болон хангамжийн зүйлсийн төвлөрсөн худалдан авалтыг хариуцах тусгай зорилго бүхий байгууллагыг үүсгэн байгуулж болох юм. Худалдан авалтын чиг үүргийн ийм төвлөрүүлэлт нь худалдааны хөнгөлөлт буюу бусад тааламжтай нөхцлүүдийг олж авах илүү их боломжийг бүрдүүлдэг. Зарим улс орны хувьд худалдан авалтын төв байгууллага нь бусад байгууллагуудын нэрийн өмнөөс бараа материалын зүйлсийг худалдан авч болох боловч бусад бүх ажил гүйлгээ нь тэдгээр байгууллагуудын нэрээр хийгддэг. Өөр зарим улс оронд, худалдан авалтын төв байгууллага нь бараа материалын зүйлсийг өөрийн нэрээр худалдан авах ба түүний чиг үүрэгт дараах зүйлс хамаардаг байж болох юм:
- (a) Хөрөнгө ба хангамжийн зүйлсийг худалдан авах;
  - (б) Борлуулалт буюу санхүүгийн түрээсийн хэлбэрээр хөрөнгийг шилжүүлэх; ба/эсвэл
  - (в) Бусад байгууллагуудад ашиглуулахын тулд тээврийн хэрэгслийн бааз гэх мэт хөрөнгийн багцыг удирдан зохицуулах ба богино буюу урт хугацаагаар түрээслэх эсвэл худалдан авахад зориулж тэдгээрийг бэлэн байлгах.
47. Улсын секторын бусад байгууллагууд нь арай хязгаарлагдмал хэмжээтэй ба цөөн давтамжтайгаар түрээсийн ажил гүйлгээнд оролцдог байж болох юм. Зарим улс оронд тухайлбал, зам, далан, усан хангамжийн систем гэх мэт дэд бүтцийн хөрөнгүүдийг уламжлан өмчилж, эрхлэн ажиллуулдаг улсын секторын байгууллагууд нь тэдгээр хөрөнгүүдийн хувьд бүрэн өмчлөлийн болон үйл ажиллагааны хариуцлагыг цаашид автоматаар хүлээдэг байснаа больж байна. Улсын секторын байгууллагууд нь ийм



дэд бүтцийн хөрөнгүүдийг борлуулалт буюу санхүүгийн түрээсийн арга замаар хувийн хэвшлийн байгууллагуудад шилжүүлж болох юм. Түүнчлэн, улсын секторын байгууллагууд нь урт хугацаат биет болон дэд бүтцийн хөрөнгүүдийг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран шинээр барьж байгуулах ба тэдгээрийг барьж дуусмагц шууд худалдан авалт эсвэл санхүүгийн түрээсээр тухайн хувийн хэвшлийн байгууллагад хариуцуулах санаа зорилготой байж болно. Зарим тохиолдолд хөрөнгийн эрх ба хяналтыг улсын секторт буцаан өгөхийн өмнө, хувийн сектор нь хяналт тавих хугацааг хэлцэлд зааж өгдөг. Жишээлбэл; орон нутгийн засаг захиргаа нь эмнэлэг барьж, түүнийгээ хувийн хэвшлийн компанид хорин жилийн хугацаатай түрээслүүлэх ба тэрхүү хугацаа дууссаны дараа хөрөнгөө буцаан улсын секторын хяналтанд авдаг байж болно.

48. **Түрээслүүлэгч нь санхүүгийн түрээсийн дагуу авах түрээсийн төлбөрийн авлагыг санхүүгийн байдлын тайландаа хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө. Түрээслүүлэгч нь тухайн түрээсийн цэвэр хөрөнгө оруулалттай тэнцүү дүнгээр ийм хөрөнгийг авлага гэж толилуулна.**
49. Санхүүгийн түрээсийн хувьд түрээслүүлэгч нь хууль ёсны өмчлөлтэй холбоотой бараг бүх эрсдэл ба урамшууллыг шилжүүлдэг бөгөөд иймээс түрээсийн төлбөрийн авлагыг өөрийн хөрөнгө оруулалт ба үйлчилгээний төлөө түүнд нөхөн олгох буюу урамшуулал болгон өгөх үндсэн дүнгийн болон санхүүгийн орлогын урьдчилсан төлбөр гэж үздэг.

*Анхны хүлээн зөвшөөрөлт*

50. Анхны шууд зардлыг ихэвчлэн түрээслүүлэгч гаргадаг бөгөөд үүнд шимтгэл, хуулийн хөлс, түүнчлэн түрээсийн хэлцэл хийх, түрээсийг эрхлэн явуулахтай шууд холбоотой өсөн нэмэгдэх дотоод зардлууд хамаарна. Харин борлуулалт ба маркетингийн багийн гаргадаг зардал гэх мэт ерөнхий нэмэгдэл зардлууд нь үүнд хамаарахгүй. Үйлдвэрлэгч буюу дилер түрээслүүлэгчтэй холбоотойгоос бусад, санхүүгийн түрээсийн хувьд анхны шууд зардлыг тухайн санхүүгийн түрээсийн авлагын анхны хэмжилтэнд тусган оруулах бөгөөд түрээсийн хугацаанд хүлээн зөвшөөрөх орлогын дүнг энэ хэмжээгээр бууруулна. Анхны шууд зардал нь санхүүгийн түрээсийн авлагад автоматаар тусган орсон байдлаар уг түрээсийн нуугдмал хүүний түвшинг тодорхойлно; иймээс анхны шууд зардлыг тусад нь нэмэх шаардлагагүй юм. Түрээсийн хэлцэл хийх болон эрхлэн явуулахтай холбоотойгоор үйлдвэрлэгч буюу дилер түрээслүүлэгчийн гаргах өртгийг анхны шууд зардлын тодорхойлолтонд оруулдаггүй. Иймээс тэдгээрийг түрээсийн цэвэр хөрөнгө оруулалтаас хасаж, борлуулалтын олз, гарзыг хүлээн зөвшөөрөх үед тухайлбал, санхүүгийн түрээсийн хувьд ихэвчлэн түрээсийн хугацааны эхэнд зардал гэж хүлээн зөвшөөрнө.
51. **Санхүүгийн орлогын хүлээн зөвшөөрөлт нь уг түрээслүүлэгчийн санхүүгийн түрээсийн цэвэр хөрөнгө оруулалтаас олох өгөөжийн тогтмол үечилсэн хувь хэмжээг тусгах тийм хэв загварт үндэслэнэ.**

52. Түрээслүүлэгч нь санхүүгийн орлогыг түрээсийн хугацааны туршид системтэй ба оновчтой сууриар хуваарилахыг эрмэлздэг. Орлогын энэхүү хуваарилалт нь уг түрээслүүлэгчийн санхүүгийн түрээсийн цэвэр хөрөнгө оруулалтаас олох өгөөжийн тогтмол үечилсэн хувь хэмжээг тусгах тийм хэв загварт үндэслэнэ. Үндсэн дүн ба урьдчилж орсон санхүүгийн орлогын аль алиныг багасгахын тулд тухайн тайлант үед хамаарах ба үйлчилгээний өртгөөс бусад, түрээсийн төлбөрүүдийг уг түрээсийн нийт хөрөнгө оруулалтаас хасдаг.
53. Түрээслүүлэгчийн түрээсийн нийт хөрөнгө оруулалтыг тооцоход ашигласан, уг тооцоолсон баталгаагүй, үлдэх өртгийг үечлэн нягталж шалгана. Хэрэв уг тооцоолсон баталгаагүй, үлдэх өртөг буурсан бол түрээсийн хугацаан дахь орлогын хуваарилалтыг хянан засварлах ба аль хэдийн хуримтлуулсан дүнгийн хувьд аливаа бууралтыг нэн даруй хүлээн зөвшөөрнө.
54. **Үйлдвэрлэгч буюу дилер түрээслүүлэгч нь хөрөнгийн борлуулалтын олз, гарзыг шууд борлуулалтын хувьд уг байгууллагын баримталдаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу тухайн тайланд үед хүлээн зөвшөөрнө.**
55. **Хэрэв хүүний түвшинг зориуд бага тогтоосон бол зах зээлийн хүүний түвшнээр тогтоосон тохиолдолд хамаарах байсан хэмжээгээр тухайн хөрөнгийн борлуулалтын аливаа олз, гарзыг хязгаарлана. Түрээсийн хэлцэл хийх ба эрхлэн явуулахтай холбоотойгоор үйлдвэрлэгч буюу дилер түрээслүүлэгчийн гаргасан өртөг зардлыг уг олз, гарзыг хүлээн зөвшөөрсөн үед зардал болгон хүлээн зөвшөөрнө.**
56. Хөрөнгийг үйлдвэрлэдэг буюу борлуулдаг улсын секторын байгууллагууд нь хөрөнгийг худалдан авах эсвэл түрээслэх аль нэг сонголтыг боломжит худалдан авагч нарт санал болгож болох юм. Үйлдвэрлэгч буюу дилер түрээслүүлэгчийн эрхлэх хөрөнгийн санхүүгийн түрээс нь хоёр төрлийн орлогыг бий болгодог:
- (а) Аливаа холбогдох тоо хэмжээний буюу худалдааны хөнгөлөлтийг тусгасан, хэвийн борлуулалтын үнээр уг түрээсийн хөрөнгийг шууд борлуулснаар үүсэх олз, гарзтай тэнцүү хэмжээний олз буюу гарз; ба
  - (б) Түрээсийн хугацааны туршид санхүүгийн орлого.
57. Үйлдвэрлэгч буюу дилер түрээслүүлэгчийн түрээсийн хугацааны эхэнд хүлээн зөвшөөрөх борлуулалтын орлого нь тухайн хөрөнгийн бодит үнэ цэнэ байна, хэрэв уг бодит үнэ цэнээс бага бол зах зээлийн хүүний түвшинг ашиглан дискаунтчилсан бөгөөд тэрхүү түрээслүүлэгчид орохоор хуримтлагдах түрээсийн хамгийн төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнэ байна. Түрээсийн хугацааны эхэнд хүлээн зөвшөөрөх хөрөнгийн борлуулалтын өртөг нь тухайн түрээслэсэн хөрөнгийн өртөг байна, хэрэв өртөг өөрчлөгдсөн бол дансны үнээс уг баталгаагүй үлдэх өртгийн өнөөгийн үнэ цэнийг хассан дүн байна. Борлуулалтын орлого ба борлуулалтын өртгийн

хоорондох зөрүү нь шууд борлуулалтын хувьд тухайн байгууллагын баримталдаг бодлогын дагуу хүлээн зөвшөөрөх борлуулалтын олз буюу гарзтай тэнцүү байна.

58. Зарим тохиолдолд үйлдвэрлэгч буюу дилер түрээслүүлэгч нь зээлийн хэвийн хүүний түвшнээс бага хэмжээний хүүг үйлчлүүлэгчдэд санал болгож болох юм. Ийм хүүний түвшинг ашиглах нь тухайн ажил гүйлгээний нийт орлогоос нилээд их хэсгийг уг борлуулалтын өдөр хүлээн зөвшөөрөхөд хүргэдэг. Хэрэв хүүний түвшинг зориуд бага тогтоосон бол борлуулалтын олз, гарз гэж хүлээн зөвшөөрөх орлогыг тухайн төрлийн ажил гүйлгээнд мөрдөх байсан уг байгууллагын зээлийн хүүний хэвийн хувь хэмжээгээр тооцсон дүнгээр хязгаарлана.
59. Анхны шууд зардал нь тухайн үйлдвэрлэгч буюу дилер түрээслүүлэгчийн борлуулалтын олз, гарзтай ихэвчлэн хамааралтай байдаг тул түүнийг түрээсийн хугацааны эхлэлийн өдөр зардал гэж хүлээн зөвшөөрнө.
60. **Түрээслүүлэгч нь санхүүгийн түрээсийн хувьд дараах зүйлсийг тодруулна:**
- (a) **Тухайн тайлангийн өдрийн байдлаарх түрээсийн нийт хөрөнгө оруулалт ба тэрхүү өдрөөрх түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн авлагын өнөөгийн үнэ цэнийн хоорондох тохируулгын тайлан. Түүнчлэн, байгууллага нь түрээсийн нийт хөрөнгө оруулалт ба тухайн тайлангийн өдрийн байдлаарх түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн авлагын өнөөгийн үнэ цэнийг дараах тайлант үе тус бүрээр тодруулна:**
    - (i) **Нэг жилээс илүүгүй;**
    - (ii) **Нэг жилээс илүү боловч таван жилээс илүүгүй; ба**
    - (iii) **Таван жилээс илүү;**
  - (б) **Урьдчилж орсон санхүүгийн орлого;**
  - (в) **Түрээслүүлэгчийн өгөөж байдлаар хуримтлагдах баталгаагүй үлдэх өртөг;**
  - (г) **Түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн найдваргүй авлагын хуримтлагдсан хасагдуулга;**
  - (д) **Санхүүгийн үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрсөн болзошгүй түрээс; ба**
  - (e) **Түрээслүүлэгчийн материаллаг дүн бүхий түрээсийн хэлцлүүдийн ерөнхий тайлбар тодорхойлолт.**
61. Хүчингүй болгосон түрээстэй холбоотой дүнгүүдийг хассаны дараах, тухайн тайлант үеийн туршид нэмэгдсэн шинэ бизнест оруулсан нийт хөрөнгө оруулалтаас урьдчилж орсон орлогыг хассан дүнг түрээсийн үйл ажиллагааны өсөлтийн үзүүлэлт болгон мөн тодруулах нь ихэвчлэн чухал ач холбогдолтой байдаг.

**Үйл ажиллагааны түрээс**

62. **Түрээслүүлэгч нь үйл ажиллагааны түрээст хамаарах хөрөнгийг өөрийн санхүүгийн байдлын тайландаа тухайн хөрөнгийн шинж төрлийн дагуу толилуулна.**
63. **Системтэй өөр суурь нь тухайн түрээслэсэн хөрөнгөөс олох өгөөжийн буурах цаг хугацааны хэв маягийг илүү сайн төлөөлөн илэрхийлэхээс бусад тохиолдолд үйл ажиллагааны түрээсээс олох түрээсийн орлогыг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын сууриар орлого гэж хүлээн зөвшөөрнө.**
64. Түрээсийн орлого олохтой холбоотойгоор гарсан өртөг зардлыг, үүн дотроо элэгдлийг зардал гэж хүлээн зөвшөөрнө. Системтэй өөр суурь нь тухайн түрээслэсэн хөрөнгөөс олох ашиглалтын өгөөжийн буурах цаг хугацааны хэв маягийг илүү сайн төлөөлөн илэрхийлэхээс бусад тохиолдолд хэдийгээр мөнгөн орлогыг шулуун шугамын сууриар хүлээн авдаггүй ч гэсэн түрээсийн орлогыг (даатгал, засвар үйлчилгээ гэх мэт үзүүлсэн үйлчилгээний орлого үүнд хамаарахгүй) шулуун шугамын сууриар орлого гэж хүлээн зөвшөөрнө.
65. **Үйл ажиллагааны түрээсийн хэлцэл хийх ба эрхлэн явуулахдаа түрээслүүлэгчийн гаргасан анхны шууд зардлыг тухайн түрээслэсэн хөрөнгийн дансны үнэ дээр нэмж, тэрхүү түрээсийн хугацааны туршид түрээсийн орлоготой ижил сууриар зардал гэж хүлээн зөвшөөрнө.**
66. **Түрээслэсэн, элэгдэх хөрөнгийн элэгдлийн бодлого нь түрээслүүлэгчийн адилтгах хөрөнгийн элэгдлийн ердийн бодлоготой нийцсэн байх бөгөөд элэгдлийг УСНББОУС 17 ба УСНББОУС 31-ийн аль тохиромжтой стандартын дагуу тооцоолно.**
67. Түрээслэсэн хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэхийг тодорхойлохын тулд байгууллага нь олон улсын ба/буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн стандартад заасан, үнэ цэнийн бууралтын холбогдох сорилыг хийнэ.
68. Үйл ажиллагааны түрээс нь борлуулалттай адилтгах ажил гүйлгээ биш учраас үйлдвэрлэгч буюу дилер түрээслүүлэгч нь ийм түрээсийн гэрээ байгуулснаар ямар нэг борлуулалтын олз хүлээн зөвшөөрөхгүй.
69. **Түрээслүүлэгч нь үйл ажиллагааны түрээсийн хувьд дараах зүйлсийг тодруулна:**
  - (a) **Үл цуцлагдах үйл ажиллагааны түрээсийн дагуу нийтдээ болон дараах тайлант үе тус бүрийн хувьд төлөх ирээдүйн түрээсийн хамгийн бага төлбөрүүд:**
    - (i) **Нэг жилээс илүүгүй;**
    - (ii) **Нэг жилээс илүү боловч таван жилээс илүүгүй; ба**

- (iii) Таван жилээс илүү;
- (б) Тухайн тайлант үед санхүүгийн үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрсөн нийт болзошгүй түрээс; ба
- (в) Түрээслүүлэгчийн түрээсийн хэлцлүүдийн ерөнхий тайлбар тодорхойлолт.

### **Борлуулах ба буцаан түрээслэх ажил гүйлгээ**

- 70. Борлуулах ба буцаан түрээслэх ажил гүйлгээ нь хөрөнгийн борлуулалт ба тэрхүү хөрөнгөө буцаан түрээслэх ажиллагааг хамардаг. Түрээсийн төлбөр ба борлуулалтын үнийг багц байдлаар хэлэлцэн тохирдог тул тэдгээр нь хоорондоо ихэвчлэн харилцан хамааралтай байдаг. Борлуулах ба буцаан түрээслэх ажил гүйлгээний нягтлан бодох бүртгэлийн хандлага нь холбогдох түрээсийн төрлөөс хамааралтай байдаг.
- 71. **Борлуулах ба буцаан түрээслэх ажил гүйлгээ нь санхүүгийн түрээс бий болгох үр дүнтэй бол борлуулагч-түрээслэгч нь дансны үнээс давсан борлуулалтын орлогын аливаа хэтэрсэн дүнг орлого гэж нэн даруй хүлээн зөвшөөрөхгүй. Харин үүнийг хойшлуулж, түрээсийн хугацаанд хорогдуулна.**
- 72. Хэрэв буцаан түрээслэлт нь санхүүгийн түрээс бол уг ажил гүйлгээ нь тухайн хөрөнгөөр хамгаалалт болгосноор түрээслүүлэгчээс түрээслэгчид санхүүжилт олгох арга хэрэгсэл болдог. Ийм учраас дансны үнээс давсан борлуулалтын орлогын дүнг орлого гэж үзэх нь тохиромжгүй юм. Энэхүү хэтэрсэн дүнг хойшлуулж, түрээсийн хугацаанд хорогдуулна.
- 73. **Борлуулах ба буцаан түрээслэх ажил гүйлгээ нь үйл ажиллагааны түрээс бий болгох үр дүнтэй бөгөөд тухайн ажил гүйлгээг бодит үнэ цэнээр хийдэг гэдэг нь тодорхой ойлгомжтой бол аливаа олз буюу гарзыг нэн даруй хүлээн зөвшөөрнө. Борлуулалтын үнэ нь бодит үнэ цэнээс бага бол гарзыг хойшлуулж, зах зээлийн үнээс бага хэмжээгээр тогтоох ирээдүйн түрээсийн төлбөрүүдээр түүнийг нөхөх ба тухайн хөрөнгийг ашиглахаар хүлээгдэж буй хугацааны туршид түрээсийн төлбөртэй хувь нийлүүлэн хорогдуулахаас бусад тохиолдолд аливаа олз буюу гарзыг нэн даруй хүлээн зөвшөөрнө. Борлуулалтын үнэ нь бодит үнэ цэнээс илүү бол бодит үнэ цэнээс давсан тэрхүү илүү дүнг хойшлуулж, тухайн хөрөнгийг ашиглахаар хүлээгдэж буй хугацаанд хорогдуулна.**
- 74. Буцаан түрээслэлт нь үйл ажиллагааны түрээс бөгөөд уг түрээсийн төлбөрүүд болон борлуулалтын үнэ нь бодит үнэ цэнээр тогтоогдсон бол энэ нь үнэн хэрэгтээ хэвийн борлуулалтын ажил гүйлгээ болох ба аливаа олз, гарзыг нэн даруй хүлээн зөвшөөрнө.
- 75. **Үйл ажиллагааны түрээсийн хувьд борлуулах ба буцаан түрээслэх ажил гүйлгээний өдрийн бодит үнэ цэнэ нь тухайн хөрөнгийн дансны үнээс бага бол уг дансны үнэ ба бодит үнэ цэнийн хоорондох зөрүүтэй тэнцүү байх гарзыг нэн даруй хүлээн зөвшөөрнө.**

76. Санхүүгийн түрээсийн хувьд (а) үнэ цэнийн бууралт гарсан, ба (б) үнэ цэнийн бууралтын талаар уг байгууллагын баримталдаг аливаа олон улсын ба/буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрөх шаардлагатай байхаас бусад тохиолдолд ийм тохируулга хийх шаардлагагүй юм.
77. Борлуулах ба буцаан түрээслэх ажил гүйлгээний тодруулгын шаардлагуудыг түрээслэгч ба түрээслүүлэгчийн хувьд нэгэн адил мөрдөнө. Материаллаг хэмжээний түрээсийн хэлцлүүдийн хувьд шаардлагатай тайлбар тодорхойлолт нь борлуулах ба буцаан түрээслэх ажил гүйлгээний хэлцэл буюу нөхцлүүдийн хэвийн бус болон онцлог заалтуудын талаар тодруулга хийхэд хүргэдэг.
78. Борлуулах ба буцаан түрээслэх ажил гүйлгээг УСНББОУС 1-ийн дагуу тусдаа тодруулахыг шаардаж болох юм.

### Шилжилтийн нөхцөл

79. [Хассан]
80. [Хассан]
81. **83-р параграфт зааснаас бусад тохиолдолд, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийг аль хэдийнээс мөрдсөн бөгөөд УСНББОУС-ыг батлагдан гармагц даган мөрдөхийг эрмэлздэг байгууллагууд нь энэ Стандартыг буцаах горимоор мөрдөхийг дэмжих боловч ингэж мөрдөхийг тэднээс заавал шаардахгүй. Хэрэв энэхүү Стандартыг буцаах горимоор мөрддөггүй бол өмнө нь оршин байсан, санхүүгийн түрээсийн аливаа үлдэгдлийг уг түрээслүүлэгч үнэн зөв тодорхойлсон гэж төсөөлөх ба тэрхүү өдрөөс хойш түүнийг энэ Стандартын нөхцлүүдийн дагуу тайлагнана.**
82. Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийг аль хэдийнээс мөрдсөн бөгөөд УСНББОУС-ыг батлагдан гармагц даган мөрдөхийг эрмэлздэг байгууллагууд нь өмнө байсан бөгөөд санхүүгийн байдлын тайландаа хөрөнгө, өр төлбөр гэж хүлээн зөвшөөрсөн санхүүгийн түрээстэй байж болох юм. Одоо байгаа санхүүгийн түрээст энэ Стандартыг буцаах горимоор мөрдөхийг дэмжинэ. Буцаах горимоор мөрдөлт нь ийм хөрөнгө ба өр төлбөрийг дахин тайлагнахад хүргэж болох юм. Энэ Стандартыг зөвхөн буцаах горимоор мөрддөг тохиолдолд ийм хөрөнгө, өр төлбөрийг дахин тайлагнахыг шаардана.
83. **УСНББОУС 13 (2001)-ыг өмнө нь мөрдөж байсан байгууллага нь энэ Стандартаар оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг уг УСНББОУС 13 (2001)-ын дагуу хүлээн зөвшөөрсөн бүх түрээстээ буцаах горимоор мөрдөнө. Харин УСНББОУС 13 (2001)-ыг буцаах горимоор мөрддөггүй бол энэ Стандартаар оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг тэрхүү УСНББОУС 13 (2001)-ыг анх мөрдсөн өдрөөс хойш байгуулсан бөгөөд түүний дагуу хүлээн зөвшөөрсөн бүх түрээстээ мөрдөнө.**

84. УСНББОУС 13 (2001)-ын шилжилтийн нөхцөл нь уг Стандартыг анх мөрдсөн өдрөөс эхлэн бүх түрээсийг хүлээн зөвшөөрөхөд таван жил хүртэлх хугацааг байгууллагуудад олгодог. УСНББОУС 13 (2001)-ыг өмнө нь мөрдөж байсан байгууллагууд нь уг УСНББОУС 13 (2001)-ыг анх мөрдсөн өдрөөс эхлэн энэхүү таван жилийн шилжилтийн хугацааны давуу талыг ашигласаар байж болох юм.
- 84А **УСНББОУС 13 (2006)-ыг өмнө нь мөрдөж байсан байгууллага нь 85А параграфт дурдсан нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдөж эхэлсэн өдрөөрх хугацаа дуусаагүй байгаа түрээсийн газрын элементүүдийн ангиллыг тэрхүү түрээс үүссэн үед оршин байсан мэдээлэлд үндэслэн дахин хянан үнэлнэ. Санхүүгийн түрээс гэж шинээр ангилсан түрээсийг УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-ны дагуу буцаах горимоор хүлээн зөвшөөрнө. Гэвч уг нэмэлт өөрчлөлтүүдийг буцаах горимоор мөрдөхөд шаардлагатай мэдээлэл байхгүй бол байгууллага нь:**
- (a) нэмэлт өөрчлөлтүүдийг баталсан өдрөөр оршин буй баримт материал болон нөхцөл байдалд үндэслэн уг нэмэлт өөрчлөлтүүдийг тухайн түрээст мөрдөнө; ба
  - (б) санхүүгийн түрээс гэж шинээр ангилсан газрын түрээстэй холбоотой хөрөнгө, өр төлбөрийг тухайн өдрөөрх тэдгээрийн бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрнө; тэдгээр бодит үнэ цэнүүдийн хоорондох аливаа зөрүүг хуримтлагдсан ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

### Хүчин төгөлдөр болох хугацаа

85. Байгууллага нь энэхүү Стандартыг 2008 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2008 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 85А. 2010 оны 11 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Сайжруулалтууд*-аар 19 ба 20-р параграфыг хасаж, 20А, 84А параграфыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2012 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2012 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 85Б. 2011 оны 10 дугаар сард гаргасан УСНББОУС 32, *Үйлчилгээний Концессын Хэлцэл: Эрх бүхий этгээд*-ийн үр дүнд 25, 26, 27-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2014 оны 01 дүгээр сарын 01-нд буюу

түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2014 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд УСНББОУС 32, түүнчлэн УСНББОУС 5-ын 6, 42А параграфуудын нэмэлт өөрчлөлт, УСНББОУС 17-гийн 5, 7, 107В параграфуудын нэмэлт өөрчлөлт, УСНББОУС 29-ийн 2, 125А параграфуудын нэмэлт өөрчлөлт, УСНББОУС 31-ийн 6, 132А параграфуудын нэмэлт өөрчлөлтийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.

- 85В. 2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-ийн үр дүнд 79, 80, 86-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед УСНББОУС 33-ыг мөрдсөн бол эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.
- 85Г. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 3 ба 4-р параграфуудыг хассан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
86. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

### **УСНББОУС 13 (2001)-аас татгалзах**

87. Энэ Стандарт нь 2001 онд гаргасан УСНББОУС 13, *Түрээс*-ийг орлоно.



## Дүгнэлтийн Үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 13-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### **НББОУС3-ийн Ерөнхий Сайжруулалтын Төсөл 2003-ын үр дүнд УСНББОУС 13-ыг хянан засварласан.**

*Оршил*

- ДҮ1. УСНББОУС3-ийн СТОУС-тай нийцүүлэх хөтөлбөр нь УСНББОУС3-ийн ажлын хөтөлбөрийн чухал элемент юм. УСНББОУС3-ийн бодлого нь улсын секторын байгууллагуудад тохиромжтой тохиолдолд НББОУС3-өөс гаргасан СТОУС-тай аккруэл суурьт УСНББОУС-ыг нийцүүлэх явдал юм.
- ДҮ2. Улсын секторын хувьд гажих тусгай учир шалтгаан байхаас бусад тохиолдолд СТОУС-тай нийцүүлсэн, аккруэл суурьт УСНББОУС нь СТОУС-ын шаардлага, бүтэц, текстийг тэр хэвээр хадгална. СТОУС-ын шаардлага буюу нэр томъёо нь улсын секторт тохиромжгүй эсвэл улсын секторын хувьд зарим тодорхой шаардлагуудыг үлгэрчлэн харуулахын тулд нэмэлт тайлбар буюу жишээ оруулах шаардлагатай тохиолдолд адилтгах СТОУС-аас гаждаг. УСНББОУС-ууд ба тэдгээртэй адилтгах СТОУС-уудын хоорондох ялгаатай талуудыг УСНББОУС нэг бүрд тусган оруулсан *СТОУС-тай Харьцуулалт*-д тодорхойлсон.
- ДҮ3. 2002 оны 5 дугаар сард өөрийн Ерөнхий Сайжруулалтын Төслийн нэг хэсэг болгон НББОУС3 нь 13-н НББОУС<sup>2</sup>-д оруулахаар санал болгосон нэмэлт өөрчлөлтийн саналын төслийг гаргасан. НББОУС3-ийн Ерөнхий Сайжруулалтын Төслийн зорилго нь “Стандартуудын хүрээн дэх сонголтод олон хувилбарууд, илүүдэл зүйлс, зөрчилтэй заалтуудыг арилгах буюу бууруулах, нийцүүлэлтийн зарим асуудлуудыг шийдэх ба бусад сайжруулалтыг хийх”-д оршино. НББОУС-ын эцсийн хувилбарыг 2003 оны 12 дугаар сард гаргасан.
- ДҮ4. 2001 оны 12 дугаар сард гаргасан УСНББОУС 13 нь НББОУС 17, *Түрээс* (1997 онд хянан засварласан)-т үндэслэсэн. НББОУС 17-г 2003 оны 12 дугаар сард дахин гаргасан. УСНББОУС3-ийн өмнөх байгууллага болох Улсын Секторын Хороо (УСХ)<sup>3</sup> нь 2003 оны 12 дугаар сард гаргасан, сайжруулсан НББОУС-тай тохиромжтой хэмжээгээр УСНББОУС-ыг нийцүүлэхийн тулд УСНББОУС-ыг сайжруулах төслийг 2003 оны эцсээр хэрэгжүүлж эхэлсэн.

<sup>2</sup> НББОУС3-ийн өмнөх байгууллага болох НББОУСХ-ноос НББОУС-ыг гаргасан. НББОУС3-өөс гаргасан стандартуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) гэж нэрлэдэг. СТОУС-ыг НББОУС3 нь СТОУС, НББОУС, Стандартын Тайлбаруудаас бүрдэнэ гэж тодорхойлсон. Зарим тохиолдолд НББОУС3 нь НББОУС-ыг сольж орлуулахгүй, харин нэмэлт өөрчлөлт оруулдаг бөгөөд ингэснээр хуучин НББОУС-ын дугаарлалт хэвээр үлддэг.

<sup>3</sup> ДНБХ-ны Зөвлөл нь УСХ-г стандарт тогтоох бие даасан зөвлөл болгохын тулд түүний бүрэн эрхийг 2004 оны 11 дүгээр сард өөрчилснөөр УСХ нь УСНББОУС3 болсон.

ДҮ5. УСНББОУСЗ нь уг сайжруулсан НББОУС 17-г нягталж шалгаад ингэж хянан засварлах болсон НББОУСЗ-ийн учир шалтгаан болон хийсэн нэмэлт өөрчлөлттэй ерөнхийдөө санал нэгдсэн. (НББОУСЗ-ийн Дүгнэлтийн Үндэслэлийг энд дахин нийтлээгүй болно. НББОУСЗ-ийн *Цогц Захиалгын Үйлчилгээ*-гээр захиалагч нар нь [www.iasb.org](http://www.iasb.org) хаягаар орж, НББОУСЗ-ийн вэб сайтаас Дүгнэлтийн Үндэслэлийг үзэж болно). УСНББОУС нь адилтгах НББОУС-аас гажих тохиолдолд улсын секторын хувьд гажих тусгай учир шалтгааныг Дүгнэлтийн Үндэслэлд тайлбарладаг.

ДҮ6. 2003 оны 12 дугаар сараас хойш гаргасан СТОУС-уудын үр дүнд НББОУС 17-д цаашид нэмэлт өөрчлөлт оруулсан. 2003 оны 12 дугаар сараас хойш гаргасан СТОУС-уудын үр дүн болох нэмэлт өөрчлөлтүүдийг УСНББОУС 13-д тусган оруулаагүй байна. Яагаад гэвэл, УСНББОУСЗ нь тэдгээр СТОУС-уудын шаардлагуудыг нягтлан шалгаж, улсын секторын байгууллагуудад мөрдөгдөх боломжит байдлын талаар өөрийн үзэл бодлыг хараахан илэрхийлээгүй байгаа юм.

**2009 онд гаргасан, НББОУСЗ-ийн СТОУС-ын Сайжруулалтууд-ын үр дүнд УСНББОУС 13-д хийсэн хянан засварлалт**

ДҮ7. УСНББОУСЗ нь 2009 оны 4 дүгээр сард НББОУСЗ-өөс гаргасан *СТОУС-ын Сайжруулалтууд*-д тусгасан, НББОУС 17-гийн хянан засварлалтыг нягталж шалгаад уг Стандартыг хянан засварлах болсон НББОУСЗ-ийн учир шалтгаантай ерөнхийдөө санал нийлсэн. УСНББОУСЗ нь уг нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдөхгүй байх улсын секторын тусгай учир шалтгаан байхгүй гэж дүгнэсэн.

**2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУСЗ-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 13-д хийсэн хянан засварлалт**

ДҮ8. УСНББОУСЗ нь 2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (а) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын зэрэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р* параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.


## **Хэрэгжүүлэх заавар удирдамж**

*Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 13-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### **Түрээсийн ангилал**


- ХЗУ1. Дараагийн хуудсанд харуулсан схемийн зорилго нь түрээсийг санхүүгийн түрээс эсвэл үйл ажиллагааны түрээс гэж ангилахад туслах явдал юм. Санхүүгийн түрээс нь хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлдэг түрээс юм. Үйл ажиллагааны түрээс нь санхүүгийн түрээс бусад түрээс юм.
- ХЗУ2. Энэ схемд тусгасан жишээ нь түрээсийг санхүүгийн түрээс гэж ангилж болох бүх боломжит нөхцөл байдлуудыг заавал тусгах албагүй бөгөөд энэхүү схемд баримталсан арга замаар түрээсийг санхүүгийн түрээс гэж заавал ангилах ёсгүй юм. Түрээс нь санхүүгийн түрээс эсвэл үйл ажиллагааны түрээс эсэх нь гэрээний хэлбэрээс биш, харин ажил гүйлгээний мөн чанараас хамаардаг (15-р параграф).
- ХЗУ3. Уг блок схемд хаалтанд харуулсан тоо нь энэ Стандартын параграфын дугаарыг илэрхийлнэ.

ТҮРЭЭС




## Түрээслүүлэгчийн санхүүгийн түрээсийн тайлагнал

ХЗУ4. Уг блок схемд хаалтанд харуулсан тоо нь энэ Стандартын параграфын дугаарыг илэрхийлнэ.



## Түрээслэгчийн санхүүгийн түрээсийн тайлагнал

ХЗУ5. Уг блок схемд хаалтанд харуулсан тоо нь энэ Стандартын параграфын дугаарыг илэрхийлнэ.



**Үйл ажиллагааны түрээс бий болоход хүргэх, борлуулах ба буцаан түрээслэх ажил гүйлгээ**

ХЗУ6. Үйл ажиллагааны түрээс бий болоход хүргэх, борлуулах ба буцаан түрээслэх ажил гүйлгээ нь олз эсвэл гарз үүсгэж болох бөгөөд түүний тодорхойлолт, хандлага (арга) нь тухайн түрээслэсэн хөрөнгийн дансны үнэ, бодит үнэ цэнэ, борлуулалтын үнээс хамаардаг. Янз бүрийн нөхцөл байдал дахь энэ Стандартын шаардлагуудыг дараах хүснэгтэнд харуулав.

<b>Бодит үнэ цэнээр тогтоосон борлуулалтын үнэ (65-р параграф)</b>	<b>Бодит үнэ цэнэтэй тэнцүү дансны үнэ</b>	<b>Дансны үнэ нь бодит үнэ цэнээс бага</b>	<b>Дансны үнэ нь бодит үнэ цэнээс их</b>
<b>Олз</b>	Олз байхгүй	Олзыг нэн даруй хүлээн зөвшөөрөх	Олз байхгүй
<b>Гарз</b>	Гарз байхгүй	Гарз байхгүй	Гарзыг нэн даруй хүлээн зөвшөөрөх

<b>Борлуулалтын үнэ нь бодит үнэ цэнээс бага (65-р параграф)</b>	<b>Дансны үнэ нь бодит үнэ цэнэтэй тэнцүү</b>	<b>Дансны үнэ нь бодит үнэ цэнээс бага</b>	<b>Дансны үнэ нь бодит үнэ цэнээс их</b>
<b>Олз</b>	Олз байхгүй	Олзыг нэн даруй хүлээн зөвшөөрөх	Олз байхгүй (Тэмдэглэл 1)
<b>Гарз нь зах зээлийн үнээс бага ирээдүйн түрээсийн төлбөрүүдээр нөхөгдөхгүй.</b>	Гарзыг нэн даруй хүлээн зөвшөөрөх	Гарзыг нэн даруй хүлээн зөвшөөрөх	(Тэмдэглэл 1)
<b>Гарз нь зах зээлийн үнээс бага ирээдүйн түрээсийн төлбөрүүдээр нөхөгдсөн.</b>	Гарзыг хойшлуулах ба хорогдуулах	Гарзыг хойшлуулах ба хорогдуулах	(Тэмдэглэл 1)

<b>Борлуулалтын үнэ нь бодит үнэ цэнээс их (65-р параграф)</b>	<b>Дансны үнэ нь бодит үнэ цэнэтэй тэнцүү</b>	<b>Дансны үнэ нь бодит үнэ цэнээс бага</b>	<b>Дансны үнэ нь бодит үнэ цэнээс их</b>
<b>Олз</b>	Олзыг хойшлуулах ба хорогдуулах	Олзыг хойшлуулах ба хорогдуулах (Тэмдэглэл 2)	Олзыг хойшлуулах ба хорогдуулах (Тэмдэглэл 3)
<b>Гарз</b>	Гарз байхгүй	Гарз байхгүй	(Тэмдэглэл 1)

Тэмдэглэл 1. Хүснэгтийн эдгээр хэсэг нь энэ Стандартын 75-р параграфын дагуу авч үзэх нөхцөл байдлуудыг илэрхийлнэ. Борлуулах ба буцаан түрээслэх ажиллагаанд хамаарах тохиолдолд тухайн хөрөнгийн дансны үнийг түүний бодит үнэ цэнэ хүртэл бууруулахыг энэ Стандартын 75-р параграфтаар шаардсан байдаг.

Тэмдэглэл 2. Хэрэв борлуулалтын үнэ нь бодит үнэ цэнээс илүү бол бодит үнэ цэнээс давсан уг илүү дүнг хойшлуулж, тухайн хөрөнгийг ашиглахаар хүлээгдэж буй хугацаанд хорогдуулна (73-р параграф).

Тэмдэглэл 3. Дансны үнийг 75-р параграфын дагуу бодит үнэ цэнэ хүртэл бууруулах тул олз нь уг бодит үнэ цэнэ ба борлуулалтын үнийн хоорондох зөрүү байна.

### Санхүүгийн түрээсийн нуугдмал хүүний түвшинг тооцоолох

ХЗУ7. Санхүүгийн түрээсийн дагуу олж эзэмшсэн хөрөнгийн түрээслэгч нь практик боломжтой тохиолдолд түрээсийн нуугдмал хүүний түвшинг тооцоолохыг энэхүү Стандарт (28-р параграф)-аар шаардсан байдаг. Түрээслэгч нь түрээсийн нуугдмал хүүний түвшинг ашигласнаар түрээсийн төлбөрүүдийг санхүүгийн зардал ба өр төлбөрийн бууралтанд төсөвлөн хуваарилахыг 34-р параграфтаар шаарддаг. Түрээсийн олон гэрээнд уг түрээсийн нуугдмал хүүний түвшинг шууд тодорхойлдог боловч зарим гэрээнд ингэж заадаггүй. Хэрэв түрээсийн нуугдмал хүүний түвшинг тухайн түрээсийн гэрээнд тодорхойлоогүй бол түрээслэгч нь өнөөгийн үнэ цэнийн томъёог ашигласнаар хүүний түвшинг тооцоолох шаардлагатай. Түрээсийн нуугдмал хүүний түвшинг санхүүгийн тооны машин болон хүснэгтэн боловсруулалтын программ хангамжаар шууд тооцоолдог. Эдгээр хэрэгсэл байхгүй тохиолдолд байгууллага нь хүүний түвшинг гараар тооцоолохын тулд өнөөгийн үнэ цэнийн томъёог ашиглаж болно. Хүүний түвшинг тооцоолох “шалгалт ба алдаа”, “интерполяци” гэсэн дараах хоёр нийтлэг аргыг энэхүү заавар удирдамжинд үлгэрчлэн харуулав. Энэхүү хоёр аргын аль аль нь хүүний түвшинг тооцоохын тулд өнөөгийн үнэ цэнийн томъёог ашигладаг.

ХЗУ8. Өнөөгийн үнэ цэнийн томъёоны гаргалгаа нь нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн сурах бичигт түгээмэл байдаг. Түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн (ТХБТ) өнөөгийн үнэ цэнийг (PV) дараах томъёогоор тооцоолно:

$$PV(ТХБТ) = \frac{S}{(1+r)^n} + \frac{A}{r} \left[ 1 - \frac{1}{(1+r)^n} \right]$$

Энд:

“S” нь баталгаатай, үлдэх өртөг

“A” нь тогтмол үечилсэн төлбөр

“r” нь аравтын бутархайгаар илэрхийлсэн, түрээсийн үечилсэн нуугдмал хүүний түвшин

“n” нь түрээсийн хугацаан дахь тайлант үеийн тоо



*Жишээ*

ХЗУ8. “Х” хэлтэс нь тээврийн хэрэгслийг санхүүгийн түрээсээр худалдан авах гэрээ байгуулсан. Түрээс үүссэн өдрөөрх уг тээврийн хэрэгслийн бодит үнэ цэнэ нь 25,000 мөнгөн нэгж, жил тутмын түрээсийн төлбөр нь 5,429 мөнгөний нэгж, түрээсийн хугацаа 4 жил, баталгаатай үлдэх өртөг нь 10,000 мөнгөн нэгж байна. Тээврийн хэрэгслийг нийлүүлэхээс өөр бусад ямар нэг үйлчилгээг түрээсийн гэрээний дагуу үзүүлэхгүй. Тус “Х” хэлтэс нь тээврийн хэрэгслийн бүх урсгал зардлыг, үүн дотроо даатгал, түлш шатахуун, засвар үйлчилгээг хариуцна. Түрээсийн нуугдмал хүүний түвшинг уг түрээсийн гэрээнд тусгайлан заагаагүй. Уг хэлтсийн зээлийн өсөн нэмэгдэх хүүний түвшин нь жил бүр 7 хувь байна. Нилээд хэдэн санхүүгийн байгууллага нь тээврийн хэрэгсэл барьцаалж, 7.5-10 хувийн хүүтэй зээл олгохоор зарласан байсан.

*Шалгалт ба алдааны арга*

ХЗУ9. Тооцоолол нь дахин давтагдах үйл явц юм. Өөрөөр хэлбэл, түрээслэгч нь хүүний түвшний талаар “хамгийн сайн таамаглал”-ыг хийх ба түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийг тооцоолж, үр дүнг нь тухайн түрээс үүссэн өдрөөрх уг түрээслэсэн хөрөнгийн бодит үнэ цэнэтэй харьцуулах ёстой. Хэрэв үр дүн нь бодит үнэ цэнээс бага бол уг сонгон авсан хүүний түвшин нь хэт өндөр; харин үр дүн нь бодит үнэ цэнээс их бол сонгон авсан хүүний түвшин нь хэт бага гэсэн үг юм. Түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнэ нь тухайн түрээс үүссэн өдрөөрх тэрхүү түрээслэсэн хөрөнгийн бодит үнэ цэнэтэй тэнцүү байх тохиолдолд ашигласан хүүний түвшин нь уг түрээсийн нуугдмал хүүний түвшин байна.

ХЗУ10. “Х” хэлтэс нь хамгийн сайн тооцооллыг ашигласнаар нуугдмал хүүний түвшинг тооцоолж эхэлсэн. Жишээлбэл; түүний өсөн нэмэгдэх зээлийн хүүний түвшин 7 хувь гэж үзэхэд хэт бага байна. Харин боломжит хамгийн өндөр хүүний түвшинг тухайлбал, тээврийн хэрэгсэл барьцаалсан зээлд санал болгох жилийн 10 хувийн хүүний түвшинг ашиглахад энэ нь хэт өндөр байна. Хэд хэдэн тооцоолол хийсний дараа, зөв буюу жилийн 8.5 хувь гэсэн хүүний түвшинд хүрнэ.

ХЗУ11. Хүүний түвшинг тооцоолохын тулд тус Хэлтэс нь дээр дурдсан, түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийн PV (ТХБТ) томъёог ашигладаг. Үүнд:

$$S=10,000 \quad n=4$$

$r$  = аравтын бутархайгаар илэрхийлэгдсэн жилийн хүүний түвшин

$$A=5,429 \quad \text{Зорилтот PV(ТХБТ)}=25,000$$

ХЗУ12. “Х” хэлтсийн зээлийн өсөн нэмэгдэх жилийн хүү 7% (0.07) (дүнг бүхэлчлэн тооцов):

$$PV(ТХБТ) = \frac{10,000}{(1 + 0.07)^4} + \frac{5,429}{0.07} \left[ 1 - \frac{1}{(1 + 0.07)^4} \right]$$

$$= 7,629 + 18,390$$

$$= 26,019$$

ХЗУ13. Өсөн нэмэгдэх зээлийн хүүний түвшинг ашигласан PV (ТХБТ) нь уг түрээслэсэн хөрөнгийн бодит үнэ цэнээс илүү тул түрээсийн нуугдмал хүүний түвшин үүнээс арай өндөр байх ёстой. Тус Хэлтэс нь бодит хүүний түвшинг тодорхойлохын тулд бусад хувь хэмжээг ашигласнаар тооцооллыг хийх ёстой (дүнг бүхэлчлэн тооцов):

7.5 хувиар тооцсон PV(ТХБТ)	=25,673	Хүүний түвшин хэт бага
10 хувиар тооцсон PV(ТХБТ)	=24,040	Хүүний түвшин хэт өндөр
9 хувиар тооцсон PV(ТХБТ)	=24,674	Хүүний түвшин хэт өндөр
8 хувиар тооцсон PV(ТХБТ)	=25,333	Хүүний түвшин хэт бага
8.5 хувиар тооцсон PV(ТХБТ)	=25,000	Зөв хүүний түвшин

ХЗУ14. Тус Хэлтэс нь доорх хүснэгтэнд харуулсанчлан, түрээсийн төлбөрүүдийг санхүүгийн зардал ба түрээсийн өр төлбөрийн бууралтанд төсөвлөн хуваарилахын тулд 8.5 хувийн хүүний түвшинг одоо ашиглана.

*Интерполяцийн арга*

ХЗУ15. Түрээсийн нуугдмал хүүний түвшний тооцоолол нь эхлээд хэт өндөр нэг хүүний түвшин ба хэт бага нэг хүүний түвшний хувьд өнөөгийн үнэ цэнийг тооцоолохыг түрээслэгчээс шаарддаг. Тооцож гаргасан үр дүнгүүд ба бодит цэвэр өнөөгийн үнэ цэнийн хоорондох зөрүүг (үнэмлэхүй дүнг) тухайн зөв хүүний түвшинд интерполяци хийхдээ ашиглана. Дээр өгөгдсөн мэдээ, түүнчлэн 7 ба 10 хувиар тооцсон үр дүнгүүдийг ашигласнаар бодит хүүний түвшинг дараах байдлаар интерполяци хийж тооцоолно (дүнг бүхэлчлэн тооцов):

7 хувиар тооцсон PV = 26,019; Зөрүү = 1,019 (өөрөөр хэлбэл, 26,019 - 25,000)

10 хувиар тооцсон PV = 24,040; Зөрүү = 960 (өөрөөр хэлбэл, 24,040 - 25,000)

$$r = 7\% + (10\% - 7\%) \frac{1,019}{(1,019 + 960)}$$

$$= 7\% + (3\% * 0.5)$$

$$= 7\% + 1.5\%$$

$$= 8.5\%$$

ТҮРЭЭС

ХЗУ16. “Х” хэлтэс нь түрээсийг өөрийн нягтлан бодох бүртгэлд тусгах ба доорх хүснэгтэнд харуулсанчлан, түрээсийн төлбөрүүдийг санхүүгийн зардал ба түрээсийн өр төлбөрийн бууралтанд төсөвлөн хуваарилахын тулд 8.5 хувийн хүүний түвшинг одоо ашиглана.

*Түрээсийн төлбөрийн төсөвлөн хуваарилалт (дүнг бүхэлчлэн тооцов)*

	Жил 0	Жил 1	Жил 2	Жил 3	Жил 4
Түрээсийн өр төлбөрийн эхний үлдэгдлийн өнөөгийн үнэ цэнэ	25,000	25,000	21,696	18,110	14,221
Хүүний зардал	-	2,125	1,844	1,539	1,209
Өр төлбөрийн бууралт	-	3,304	3,585	3,890	14,221*
Түрээсийн өр төлбөрийн эцсийн үлдэгдэл	25,000	21,696	18,110	14,221	-

\* Баталгаатай үлдэх өртгийн төлбөрийг агуулсан.

## НББОУС 17-ТОЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 13, Түрээс-ийг НББОУС 17, Түрээс-ээс үндсэндээ бэлтгэсэн бөгөөд 2009 оны 4 дүгээр сард гаргасан, *СТОУС-ын Сайжруулалтууд*-ын нэг хэсэг байдлаар НББОУС 17-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг үүнд тусгасан болно. УСНББОУС 13 ба НББОУС 17-гийн хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- УСНББОУС 13 нь зарим тохиолдолд НББОУС 17-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь УСНББОУС 13 дахь “санхүүгийн үр дүнгийн тайлан” гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. НББОУС 17 дахь адилтгах нэр томъёо нь “орлогын тайлан” юм.
- НББОУС 17-гийн хувьд “орлого” /revenue/ нэр томъёоноос илүү өргөн утгатай байдаг “орлого” /income/ нэр томъёог УСНББОУС 13-д ашигладаггүй.
- НББОУС 17 нь өөрийн техникийн нэр томъёоны цогц тодорхойлолтонд “бодит үнэ цэнэ”-ийн тодорхойлолтыг агуулсан байдаг. Энэхүү тодорхойлолтыг тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д оруулсан тул УСНББОУС 13-д тусгаагүй болно.
- УСНББОУС 13 нь түрээсийн ангилал, түрээслэгчийн санхүүгийн түрээсийн нягтлан бодох бүртгэлийн хандлага, түрээслүүлэгчийн санхүүгийн түрээсийн нягтлан бодох бүртгэлийн хандлага, санхүүгийн түрээсийн нуугдмал хүүний түвшний тооцооллыг үлгэрчлэн харуулсан хэрэгжүүлэх нэмэлт заавар удирдамжтай байдаг.

## УСНББОУС 14–ТАЙЛАНГИЙН ӨДРИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) 10, *Балансын Өдрийн Дараах Үйл Явдал* (2003 онд хянан засварласан)-аас үндсэндээ бэлтгэсэн болно. НББОУС 10-аас авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон EC4M 6XH, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)

Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.

## УСНББОУС 14-ТАЙЛАНГИЙН ӨДРИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

### УСНББОУС-ын түүх

Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

УСНББОУС 14, Тайлангийн Өдрийн Дараах Үйл Явдал-ыг 2001 оны 12 дугаар сард гаргасан.

2006 оны 12 дугаар сард УСНББОУС3 нь хянан засварласан УСНББОУС 14-ийг гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 14-т нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл (2017 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2011-ийн Сайжруулалтууд (2011 оны 10 дугаар сард гаргасан)
- УСНББОУС-ын Сайжруулалтууд (2010 оны 01 дүгээр сард гаргасан)

### УСНББОУС 14-ийн нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт

Өөрчлөгдсөн параграф	Хэрхэн өөрчилсөн	Юугаар өөрчилсөн
Танилцуулга хэсэг	Хассан	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
3	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
4	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
15	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
16	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар
21	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
31	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар УСНББОУС 40, 2017 оны 01-р сар

ТАЙЛАНГИЙН ӨДРИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

32А	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар
32Б	Шинэ	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
32В	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
32Г	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
32Д	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
33	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар

2006 оны 12 дугаар сар

**УСНББОУС 14–ТАЙЛАНГИЙН ӨДРИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ****АГУУЛГА**

	Параграф
Зорилго	1
Цар хүрээ	2-4
Тодорхойлолт	5
Санхүүгийн тайланг нийтэд гаргахыг зөвшөөрөх	6-8
Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт	9-16
Тайлангийн өдрийн дараах залруулагдах үйл явдал	10-11
Тайлангийн өдрийн дараах үл залруулагдах үйл явдал	12-13
Ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт	14-16
Тасралтгүй байх суурь	17-25
Бүтцийн өөрчлөлт	25
Тодруулга	26-31
Нийтэд гаргахыг зөвшөөрсөн өдрийн тодруулга	26-27
Тайлангийн өдрөөрх нөхцөл байдлын талаархи тодруулгыг шинэчлэн баяжуулах	28-29
Тайлангийн өдрийн дараах үл залруулагдах үйл явдлын тодруулга	30-31
Хүчин төгөлдөр болох хугацаа	32-33
УСНББОУС 14 (2001)-өөс татгалзах	34
Хавсралт: Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт	
Дүгнэлтийн үндэслэл	
НББОУС 10-тай харьцуулалт	



## ТАЙЛАНГИЙН ӨДРИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 14, *Тайлангийн Өдрийн Дараах Үйл Явдал*-ыг 1-34-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 14-ийг түүний зорилгын агуулга, Дүгнэлтийн Үндэслэл, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

1. Энэхүү Стандартын зорилго нь дараах зүйлсийг тодорхойлоход оршино:
  - (а) Байгууллага нь тайлангийн өдрийн дараах үйл явдлуудын хувьд өөрийн санхүүгийн тайланг хэзээ залруулах; ба
  - (б) Санхүүгийн тайланг нийт гаргахыг зөвшөөрсөн өдөр болон тайлангийн өдрийн дараах үйл явдлын талаар тухайн байгууллагын хийвэл зохих тодруулга.

Хэрэв тайлангийн өдрийн дараах үйл явдал нь тасралтгүй байх төсөөлөл тохиромжгүй гэдгийг илэрхийлж байвал байгууллага нь өөрийн санхүүгийн тайланг тасралтгүй байх сууриар бэлтгэхгүй байхыг энэхүү Стандартаар бас шаарддаг.

## Цар хүрээ

2. Нягтлан бодох бүртгэлийн аккрузал сууриар санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь тайлангийн өдрийн дараах үйл явдлуудыг тайлагнах ба тодруулахдаа энэ Стандартыг мөрдөнө.
3. [Хассан]
4. [Хассан]

## Тодорхойлолт

5. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

Тайлангийн өдрийн дараах үйл явдал гэдэг нь тайлангийн өдөр ба санхүүгийн тайланг нийтэд гаргахыг зөвшөөрсөн өдрийн хооронд гарч тохиолдсон тааламжтай болон тааламжгүй үйл явдлууд юм. Дараах хоёр төрлийн үйл явдлыг тодорхойлж болно:

- (а) Тайлангийн өдрөөр оршин байсан нөхцөл байдлуудыг батлан илэрхийлэх үйл явдал (тайлангийн өдрийн дараах залруулагдах үйл явдал); ба
- (б) Тайлангийн өдрийн дараа үүссэн нөхцөл байдлуудыг илэрхийлэх үйл явдал (тайлангийн өдрийн дараах үл залруулагдах үйл явдал).

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д дахин нийтэлсэн болно.

## Санхүүгийн тайланг нийтэд гаргахыг зөвшөөрөх

6. Тайлангийн өдрийн дараах үйл явдлын тодорхойлолтыг аль үйл явдал нь хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд тухайн тайлангийн өдөр ба санхүүгийн тайланг нийтэд гаргахыг зөвшөөрсөн өдрийн аль алиныг тодорхойлох шаардлагатай байдаг. Тайлангийн өдөр нь тухайн санхүүгийн тайлангийн хамаарах тайлант үеийн сүүлчийн өдөр юм. Нийтэд гаргахыг зөвшөөрсөн өдөр нь санхүүгийн тайланг нийтэд гаргахын тулд эцэслэн дуусгах бүрэн эрх бүхий хувь хүн буюу байгууллагаас тухайн санхүүгийн тайлангийн хувьд зөвшөөрөл авсан өдөр юм. Тэдгээр эцэслэн дуусгасан санхүүгийн тайланд аудитын санал дүгнэлт авдаг. Хэдийгээр үйл явдлууд нь (а) ашиг, алдагдлын мэдэгдлийн хэвлэн нийтлэлт, (б) хяналтанд буй байгууллагын санхүүгийн тайланг зөвшөөрөн батлалт, (в) тухайн санхүүгийн тайлантай холбоотой бусад сонгосон мэдээллийн хэвлэн нийтлэлт зэргийн дараа гарч тохиолдсон байлаа ч гэсэн уг тайлангийн өдөр ба санхүүгийн тайланг нийтэд гаргахыг зөвшөөрсөн өдрийн хооронд гарч тохиолдсон тааламжтай болон тааламжгүй бүх үйл явдлууд нь тайлангийн өдрийн дараах үйл явдал юм.
7. Санхүүгийн тайланг бэлтгэх, түүнчлэн түүнийг нийтэд гаргахыг зөвшөөрөхтэй холбоотой үйл явц нь улс орон бүрд болон нэг улсын янз бүрийн байгууллагуудын хувьд өөр өөр байж болох юм. Энэ нь тухайн байгууллагын шинж төрөл, удирдлагын бүтэц, уг байгууллагад хамаарах хууль эрх зүйн шаардлага болон санхүүгийн тайланг бэлтгэж, эцэслэхэд баримталдаг горимуудаас хамааран өөр өөр байдаг. Засгийн газрын бие даасан агентлагуудын санхүүгийн тайланг зөвшөөрөн батлах хариуцлага нь төв санхүүгийн агентлагийн дарга (буюу хянагч, ерөнхий нягтлан бодогч гэх мэт санхүүгийн удирдах албан тушаалтан)-д хамаарч болох юм. Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланг зөвшөөрөн батлах хариуцлагыг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дарга (буюу хянагч, ерөнхий нягтлан бодогч гэх мэт санхүүгийн удирдах албан тушаалтан) болон Сангийн сайд (буюу түүнтэй адилтгах албан тушаалтан) ихэвчлэн хамтран хүлээдэг байж болно.
8. Зөвшөөрөн батлах үйл явцын эцсийн алхам болгон байгууллага нь зарим тохиолдолд санхүүгийн тайлангаа өөр нэг этгээдэд (жишээлбэл; Улсын Их Хурал, Орон Нутгийн Иргэдийн Хурал гэх мэт хууль тогтоогч байгууллагад) танилцуулах шаардлагатай байдаг. Ийм эрх бүхий байгууллага нь аудитласан санхүүгийн тайланд өөрчлөлт оруулахыг шаардах бүрэн эрхтэй байж болно. Өөр зарим тохиолдолд санхүүгийн тайланг бусад этгээдэд танилцуулалт нь зөвхөн даган мөрдөх үйлдэл буюу үйл явц бөгөөд тэрхүү эрх бүхий этгээд нь санхүүгийн тайланд өөрчлөлт оруулах бүрэн эрхгүй байж болох юм. Санхүүгийн тайланг нийтэд гаргахыг зөвшөөрсөн өдрийг тухайн улс орны хүрээнд тодорхойлно.

## Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

9. Тайлангийн өдөр ба нийтэд гаргахыг зөвшөөрсөн өдрийн хоорондох хугацаанд Засгийн газраас томилогдсон албан тушаалтан нь тодорхой асуудалтай холбоотойгоор засгийн газрын зорилго төлөвлөгөөг зарлан мэдэгдэж болно. Засгийн газрын ийм зарлан мэдэгдсэн зорилго төлөвлөгөөг залруулагдах үйл явдал байдлаар хүлээн зөвшөөрөх шаардлагатай эсэх нь (а) ингэж зарлан мэдэгдсэнээр тухайн тайлангийн өдрөөр оршин байсан нөхцөл байдлын талаар илүү их мэдээллээр хангах эсэх, ба (б) тэдгээр зорилго төлөвлөгөөг биелүүлж чадна, биелүүлнэ гэсэн хангалттай нотолгоо байгаа эсэхээс хамаарна. Ихэнх тохиолдолд засгийн газрын зорилго төлөвлөгөөний зарлан мэдэгдэлт нь залруулагдах үйл явдлын хүлээн зөвшөөрөлтөнд хүргэдэггүй. Гэвч энэ нь үл залруулагдах үйл явдал байдлаар тодруулга хийх шалгуурыг хангадаг.

## Тайлангийн өдрийн дараах залруулагдах үйл явдал

10. **Байгууллага нь тайлангийн өдрийн дараах залруулагдах үйл явдлыг тусгахын тулд өөрийн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүнгээ залруулна.**
11. Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүнгээ залруулах эсвэл өмнө хүлээн зөвшөөрөөгүй зүйлсээ хүлээн зөвшөөрөхийг тухайн байгууллагаас шаарддаг тайлангийн өдрийн дараах ийм залруулагдах үйл явдлын жишээг доор дурдав:
- (а) Тайлангийн өдрөөр тухайн байгууллага ийм одоогийн үүрэгтэй байсан гэдгийг баталгаажуулах шүүхийн заргаан маргаан нь уг тайлангийн өдрийн дараа шийдвэрлэгдэх. Байгууллага нь энэхүү шүүхийн маргаантай холбоотойгоор УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-ийн дагуу өмнө хүлээн зөвшөөрсөн аливаа нөөцийн дүнг залруулах буюу шинээр нөөцийг хүлээн зөвшөөрнө. Зарга маргааны шийдвэрлэлт нь УСНББОУС 19-ийн 24-р параграфын дагуу харгалзан үзвэл зохих нэмэлт нотолгоогоор хангах учраас байгууллага нь болзошгүй өр төлбөрийн талаар зөвхөн тодруулга хийгээд орхихгүй юм.
- (б) Тайлангийн өдрөөр хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсвэл тухайн хөрөнгийн хувьд өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзын дүнг залруулах шаардлагатай гэдгийг илэрхийлэх мэдээллийг тэрхүү тайлангийн өдрийн дараа хүлээн авсан. Жишээлбэл:
- (i) Тайлангийн өдрийн дараа гарч тохиолдсон худалдан авагчийн дампуурал нь тэрхүү тайлангийн өдрөөр авлагын дансанд аль хэдийн гарз үүссэн байсан бөгөөд авлагын дансны үнийг тухайн байгууллага залруулах шаардлагатай байсан гэдгийг ихэвчлэн батлан илэрхийлдэг; ба

## ТАЙЛАНГИЙН ӨДРИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

- (ii) Тайлангийн өдрийн дараах бараа материалын борлуулалт нь уг тайлангийн өдрөөрх тэрхүү бараа материалын цэвэр боломжит үнэ цэнийн талаархи нотолгоо болж болох юм.
- (в) Тайлангийн өдрөөс өмнө худалдан авсан хөрөнгийн өртөг эсвэл борлуулсан хөрөнгийн орлогыг уг тайлангийн өдрийн дараа тодорхойлох;
- (г) Тухайн тайлант үеийн туршид хүчин төгөлдөр байсан орлого-хуваах гэрээний дагуу засгийн газрын өөр нэг байгууллагатай хуваах ёстой бөгөөд уг тайлант үед цуглуулсан орлогын дүнг тэрхүү тайлангийн өдрийн дараа тодорхойлсон;
- (д) Тайлангийн өдрөөс өмнөх үйл явдлын үр дүнд тухайн тайлангийн өдрөөр байгууллага нь ажиллагчиддаа үр дүнгийн урамшуулал олгох гэрээний буюу гэрээний бус одоогийн үүрэгтэй байсныг тэрхүү тайлангийн өдрийн дараа тодорхойлсон; ба
- (е) Тухайн санхүүгийн тайлан буруу гэдгийг илэрхийлэх залилан эсвэл алдааг илрүүлсэн.

### **Тайлангийн өдрийн дараах үл залруулагдах үйл явдал**

12. **Байгууллага нь тайлангийн өдрийн дараах үл залруулагдах үйл явдлыг тусгахын тулд өөрийн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүнгээ залруулахгүй.**
13. Тайлангийн өдрийн дараах үл залруулагдах үйл явдлын жишээг доор дурдав:
  - (а) Байгууллага нь үл хөдлөх хөрөнгийг бодит үнэ цэнээр байнга дахин үнэлэх бодлого баримталдаг тохиолдолд тайлангийн өдөр ба тухайн санхүүгийн тайланг нийтэд гаргахыг зөвшөөрсөн өдрийн хоорондох хугацаанд уг үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнэд гарсан бууралт. Бодит үнэ цэнийн бууралт нь тайлангийн өдрөөрх тухайн үл хөдлөх хөрөнгийн нөхцөл байдалтай ихэвчлэн холбоогүй байдаг боловч дараагийн тайлант үед үүссэн нөхцөл байдлыг тусгадаг. Иймээс байнга дахин үнэлэх түүний бодлогоос үл хамааран байгууллага нь тэрхүү үл хөдлөх хөрөнгийн хувьд өөрийн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүнг залруулахгүй. Үүнтэй адилаар, хэдийгээр байгууллага нь 29-р параграфын дагуу нэмэлт тодруулга хийх шаардлагатай байж болох боловч тайлангийн өдрөөр уг үл хөдлөх хөрөнгийн хувьд тодруулсан дүнгүүдийг шинэчлэн өөрчлөхгүй.
  - (б) Нийгмийн үйлчилгээний тодорхой хөтөлбөрүүдийг эрхлэн ажиллуулах үүрэг хүлээсэн байгууллага нь тэдгээр хөтөлбөрийн оролцогчдод шууд буюу шууд бус байдлаар нэмэлт тэтгэмж олгохоор/хуваарилахаар тайлангийн өдрийн дараа боловч уг санхүүгийн тайланг нийтэд гаргахыг зөвшөөрөхөөс өмнө шийдвэрлэсэн. Хэдийгээр нэмэлт тэтгэмж нь 29-р параграфын дагуу

## ТАЙЛАНГИЙН ӨДРИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

үл залруулагдах үйл явдал гэж тодруулах нөхцлүүдийг хангаж болох боловч байгууллага нь тухайн тайлант үед өөрийн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн зардлыг залруулахгүй.

### Ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт

14. **Хэрэв байгууллага нь тайлангийн өдрийн дараа ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг олгохоор зарласан бол уг байгууллага нь тухайн тайлангийн өдөр тэдгээр хуваарилалтыг өр төлбөр гэж хүлээн зөвшөөрөхгүй.**
15. Тухайлбал; ногдол ашиг олговол зохих гаднын өмчлөлийн хувь оролцоотой улсын секторын худалдаа арилжааны байгууллагыг тухайн улсын секторын байгууллага нь хянаж, түүний санхүүгийн тайланг нэгтгэдэг тохиолдолд улсын секторт ногдол ашиг үүсэж болно. Түүнчлэн, улсын секторын зарим байгууллага нь санхүүгийн менежментийн үзэл баримтлалыг, тухайлбал “худалдан авагч-нийлүүлэгч” загварыг ашигладаг бөгөөд төв засгийн газар гэх мэт өөрийн хяналт тавигч байгууллагад орлогын хуваарилалт олгох шаардлагатай байдаг.
16. Эздэд олгох ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг тайлангийн өдрийн дараа боловч санхүүгийн тайланг нийтэд гаргахыг зөвшөөрөхийн өмнө зарласан (өөрөөр хэлбэл, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг зохих ёсоор зөвшөөрөн баталсан ба цаашид тухайн байгууллагаас хамаарахгүй) бол энэ үед үүрэг үүсээгүй байсан тул тэрхүү ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг тухайн тайлангийн өдрөөр өр төлбөр гэж хүлээн зөвшөөрөхгүй. Ийм ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг УСНББОУС 1-ийн дагуу тодруулгад толилуулна. Капиталын буцаалт нь ногдол ашиг болон адилтгах хуваарилалтанд хамаарахгүй.

### Тасралтгүй байх суурь

17. Тасралтгүй байх төсөөлөл тохиромжтой эсэх тодорхойлолтыг байгууллага нэг бүр харгалзан үзэх шаардлагатай. Гэвч тасралтгүй байх төсөөллийн үнэлгээ нь нь бүхэлдээ засгийн газартай биш, харин тухайн бие даасан байгууллагуудад юуны өмнө хамааралтай байх магадлалтай юм. Жишээлбэл; засгийн газрын бие даасан агентлагийг өөртөө агуулдаг засгийн газар нь уг агентлагийн бүх үйл ажиллагааг засгийн газрын өөр нэг агентлагт шилжүүлэхээр шийдвэрлэсэн учраас засгийн газрын тэрхүү бие даасан агентлаг нь тасралтгүй байдлаар үйл ажиллагаагаа явуулахааргүй байж болно. Гэвч энэхүү бүтцийн өөрчлөлт нь тухайн засгийн газрын өөрийнх нь тасралтгүй байх үнэлгээнд нөлөө үзүүлэхгүй юм.
18. **Санхүүгийн тайланг бэлтгэх хариуцлага хүлээсэн этгээд эсвэл удирдах байгууллага нь (а) уг байгууллагыг татан буулгах буюу түүний үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөсөн, эсвэл (б) ингэхээс өөр бодит хувилбаргүй болсон гэдгээ тайлангийн өдрийн дараа**

**тодорхойлсон бол тухайн байгууллага нь санхүүгийн тайлангаа тасралтгүй байх сууриар бэлтгэхгүй.**

19. Бие даасан байгууллагын хувьд тасралтгүй байх төсөөлөл тохиромжтой эсэхийг үнэлэхдээ тухайн санхүүгийн тайланг бэлтгэх хариуцлага хүлээсэн этгээд ба/буюу удирдах байгууллага нь янз бүрийн хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай. Ийм хүчин зүйлсэд тухайн байгууллагын одоогийн болон хүлээгдэж буй үр дүн, зохион байгуулалтын аливаа зарлан мэдэгдсэн болон боломжит бүтцийн өөрчлөлт, засгийн газрын тасралтгүй санхүүжилт олгох магадлал, хэрэв шаардлагатай бол орлох санхүүжилтийн боломжит эх үүсвэрүүд хамаарна.
20. Үйл ажиллагаа нь үндсэндээ төсвөөс санхүүждэг байгууллагуудын хувьд засгийн газар нь тухайн байгууллагад олгох санхүүжилтийг зогсоох өөрийн санал төлөвлөгөөг зарлан мэдэгдсэн зөвхөн тийм тохиолдолд тасралтгүй байдлын асуудал ерөнхийдөө үүсдэг.
21. Улсын секторын зарим байгууллагууд нь өөрийгөө бүрэн буюу ихэнх хэсгийг санхүүжүүлэх ба бараа, үйлчилгээний өртгийг хэрэглэгчдээс нөхөн олох шаардлагатай байж болох юм. Ийм аливаа байгууллагын хувьд тайлангийн өдрийн дараах үйл ажиллагааны үр дүнгийн болон санхүүгийн байдлын доройтол нь тасралтгүй байх төсөөлөл тохиромжтой хэвээр байгаа эсэхийг харгалзан үзэх шаардлагатай гэдгийг илэрхийлж болно.
22. Хэрэв тасралтгүй байх төсөөлөл цаашид тохиромжгүй болвол энэ Стандарт нь тухайн нөхцөл байдлыг өөрийн санхүүгийн тайландаа тусгахыг уг байгууллагаас шаардана. Ийм өөрчлөлтийн үр нөлөө нь уг байгууллагын тухайн тодорхой нөхцөл байдлаас тухайлбал, үйл ажиллагааг засгийн газрын өөр нэг байгууллагад шилжүүлсэн, эсвэл түүнийг борлуулсан буюу татан буулгасан эсэхээс хамаардаг. Хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийг өөрчлөх шаардлагатай эсэхийг тодорхойлохдоо шүүн тунгаалт хийдэг.
23. Тасралтгүй байх төсөөлөл цаашид тохиромжгүй байх тохиолдолд тухайн нөхцөл байдлын өөрчлөлт нь нэмэлт өр төлбөр үүсгэхэд хүргэх эсвэл зарим өрийг богино хугацаат өр төлбөр гэж дахин ангилахад хүргэх өрийн гэрээний заалтуудыг хэрэгжүүлэх эсэхийг мөн харгалзан үзэх шаардлагатай байдаг.
24. УСНББОУС 1 нь дараах тохиолдолд зарим тодруулга хийхийг шаарддаг:
  - (а) Санхүүгийн тайланг тасралтгүй байх сууриар бэлтгээгүй байх. Санхүүгийн тайланг тасралтгүй байх сууриар бэлтгээгүй тохиолдолд УСНББОУС 1 нь энэ тухай, түүнчлэн тэрхүү санхүүгийн тайланг бэлтгэсэн суурь, уг байгууллагыг тасралтгүй байдлаар үйл ажиллагаагаа явуулж чадахгүй гэж үзсэн шалтгааны хамт тодруулахыг шаарддаг; эсвэл
  - (б) Санхүүгийн тайланг бэлтгэх хариуцлага хүлээсэн этгээд нь тасралтгүй байдлаар үйл ажиллагаагаа явуулах уг байгууллагын

чадвар боломжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал буюу нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхойгүй байдлыг мэдэх. Тодруулга хийхийг шаардах үйл явдал буюу нөхцөл байдал нь уг тайлангийн өдрийн дараа үүсэж болох юм. УСНББОУС 1 нь ийм тодорхойгүй байдлын талаар тодруулга хийхийг шаарддаг.

### **Бүтцийн өөрчлөлт**

25. Тайлангийн өдрийн дараа зарлан мэдэгдсэн бүтцийн өөрчлөлт нь үл залруулагдах үйл явдлын тодорхойлолтыг хангах тохиолдолд энэхүү Стандартын дагуу зохих тодруулгыг хийнэ. Бүтцийн өөрчлөлттэй холбоотой нөөц сангийн хүлээн зөвшөөрөлтийн талаархи заавар удирдамжийг УСНББОУС 19-өөс үзэж болно. Бүтцийн өөрчлөлт нь тухайн байгууллагын бүрэлдэхүүн хэсгийн данснаас хасалтыг угаасаа агуулдаг учраас энэ нь дангаараа уг байгууллагын тасралтгүй байдлаар үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадварт эргэлзээ үүсгэхгүй. Гэвч тайлангийн өдрийн дараа зарлан мэдэгдсэн бүтцийн өөрчлөлт нь тухайн байгууллага цаашид тасралтгүй үйл ажиллагаа явуулахгүй гэдгийг илэрхийлж байгаа тохиолдолд уг хүлээн зөвшөөрсөн хөрөнгө, өр төлбөрийн шинж төрөл болон дүн нь өөрчлөгдөж болох юм.

### **Тодруулга**

#### **Нийтэд гаргахыг зөвшөөрсөн өдрийн тодруулга**

26. **Байгууллага нь санхүүгийн тайланг нийтэд гаргахыг зөвшөөрсөн өдөр болон уг зөвшөөрлийг хэн өгсөн талаар тодруулга хийнэ. Хэрэв өөр нэг этгээд нь санхүүгийн тайланг нийтэд гаргасны дараа түүнд өөрчлөлт оруулах бүрэн эрхтэй бол уг байгууллага нь энэ тухай тодруулга хийнэ.**
27. Санхүүгийн тайланг нийтэд гаргахыг зөвшөөрсөн өдрөөс хойшхи үйл явдлыг уг санхүүгийн тайланд тусгадаггүй тул тэрхүү өдрийг мэдэж байх нь хэрэглэгчдэд ач холбогдолтой байдаг. Санхүүгийн тайланг нийтэд гаргасны дараа аливаа нэг этгээд буюу байгууллага нь түүнд нэмэлт өөрчлөлт оруулах бүрэн эрхтэй байх цөөн ховор тохиолдлыг хэрэглэгч нар мэдэж байх нь мөн чухал ач холбогдолтой юм. Санхүүгийн тайланг нийтэд гаргасны дараа түүнд нэмэлт өөрчлөлт оруулах бүрэн эрхтэй байж болох хувь хүн буюу этгээдийн жишээнд Сайд нар, тухайн байгууллага нэг хэсэг нь болдог засгийн газар, Улсын Их Хурал, иргэдийн төлөөлөгчдийн хурал хамаарна. Хэрэв өөрчлөлт оруулсан бол уг нэмэлт өөрчлөлт оруулсан санхүүгийн тайлан нь шинэ цогц санхүүгийн тайлан болно.

#### **Тайлангийн өдрөөрх нөхцөл байдлын талаархи тодруулгыг шинэчлэн баяжуулах**

28. **Хэрэв байгууллага нь тайлангийн өдрөөр оршин байсан нөхцөл байдлын талаархи мэдээллийг тухайн тайлангийн өдрийн дараа боловч санхүүгийн тайланг нийтэд гаргахыг зөвшөөрөхийн өмнө**



**хүлээн авсан бол уг шинэ мэдээлэлд үндэслэн тэдгээр нөхцөл байдалтай холбоотой тодруулгыг шинэчлэн баяжуулна.**

29. Тайлангийн өдрийн дараа боловч санхүүгийн тайланг нийтэд гаргахыг зөвшөөрөхийн өмнө хүлээн авсан мэдээлэл нь тухайн байгууллагын санхүүгийн тайланд даа хүлээн зөвшөөрсөн дүнд нөлөө үзүүлэхгүй байлаа ч гэсэн байгууллага нь уг мэдээллийг тусгахын тулд өөрийн санхүүгийн тайлан дахь тодруулгыг зарим үед шинэчлэн баяжуулах шаардлагатай байдаг. Тодруулгыг ингэж шинэчлэн баяжуулах шаардлагатай тохиолдлын нэг жишээ нь; тайлангийн өдрөөр оршин байсан болзошгүй өр төлбөрийн талаархи нотолгоо нь уг тайлангийн өдрийн дараа гарч ирэх явдал юм. Нөөцийг одоо хүлээн зөвшөөрөх хэрэгтэй эсэхийг харгалзан үзэхээс гадна байгууллага нь уг болзошгүй өр төлбөрийн талаархи тодруулгыг тэрхүү нотолгоонд үндэслэн шинэчлэн баяжуулна.

### **Тайлангийн өдрийн дараах үл залруулагдах үйл явдлын тодруулга**

30. **Хэрэв тайлангийн өдрийн дараах үл залруулагдах үйл явдал нь материаллаг дүнтэй бол түүний талаар тодруулга хийхгүй байх нь тухайн санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөө үзүүлж болох юм. Иймээс байгууллага нь тайлангийн өдрийн дараах үл залруулагдах үйл явдлын материаллаг анги тус бүрийн хувьд дараах зүйлсийг тодруулна:**

- (a) **Үйл явдлын шинж төрөл; ба**
- (б) **Уг үйл явдлын санхүүгийн үр нөлөөний тооцоолол эсвэл ийм тооцоолол хийх боломжгүй талаархи тайлбар мэдэгдэл.**

31. Тодруулга хийхэд ерөнхийдөө хүргэдэг тайлангийн өдрийн дараах үл залруулагдах үйл явдлын жишээг доор дурдав:

- (a) Бодит үнэ цэнээр бүртгэсэн үл хөдлөх хөрөнгийн тухайн тайлангийн өдрөөрх нөхцөл байдалтай холбоогүй боловч уг тайлангийн өдрөөс хойш үүссэн нөхцөл байдлын улмаас түүний үнэ цэнэд гарсан хэвийн бус том хэмжээний бууралт;
- (б) Байгууллага нь өөрийн эрхлэн ажиллуулдаг нийгмийн үйлчилгээний хөтөлбөрүүдийн оролцогчдод шууд буюу шууд бус байдлаар ирээдүйд нэмэлт тэтгэмж олгохоор/хуваарилахаар тайлангийн өдрийн дараа шийдвэрлэсэн бөгөөд тэдгээр нэмэлт тэтгэмж нь тухайн байгууллагад томоохон нөлөө үзүүлэхээр байх;
- (в) Тайлангийн өдрийн дараах улсын секторын томоохон нэгдэл (УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл* нь ийм тохиолдолд тусгай тодруулга хийхийг шаарддаг), хяналтанд буй томоохон байгууллагын данснаас хасалт, байгууллагын одоо эрхлэн явуулж буй бүх буюу бараг бүх үйл ажиллагааг аутсорсингоор гүйцэтгүүлэх;
- (г) Үйл ажиллагаа буюу томоохон хөтөлбөрийг зогсоох төлөвлөгөөг зарлан мэдэгдэх, уг зогсоосон үйл ажиллагаа буюу томоохон хөтөлбөрт хамааруулж болох хөрөнгийг данснаас хасах ба өр

## ТАЙЛАНГИЙН ӨДРИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

- төлбөрийг барагдуулах, ийм хөрөнгийг борлуулах эсвэл ийм өр төлбөрийг барагдуулах заавал биелүүлэх гэрээ байгуулах;
- (д) Хөрөнгийн томоохон худалдан авалт ба данснаас хасалт;
  - (е) Тайлангийн өдрийн дараа гарсан гал түймрийн улмаас гол барилга шатаж сүйрэх;
  - (ж) Томоохон бүтцийн өөрчлөлт хийхээр зарлах буюу хэрэгжүүлж эхлэх (УСНББОУС 19-ийг үзнэ үү);
  - (и) Хөтөлбөрийн нэг хэсэг байдлаар байгууллага буюу хувь хүмүүст олгосон зээлийг хүчингүй болгох хууль тогтоомжийг танилцуулах;
  - (к) Тайлангийн өдрийн дараа хөрөнгийн үнэд эсвэл гадаад валютын ханшид орсон хэвийн бус томоохон өөрчлөлтүүд;
  - (л) Орлогын татвар буюу түүнтэй адилтгах татвар төлөх үүрэг бүхий байгууллагуудын хувьд тайлант болон хойшлуулсан татварын хөрөнгө, өр төлбөрт мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх бөгөөд уг тайлангийн өдрийн дараа хүчин төгөлдөр болсон эсвэл зарлагдсан татварын хувь хэмжээний буюу татварын хуулийн өөрчлөлтүүд (орлогын татварын тайлагналын заавар удирдамжийг орлогын татварын талаархи олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартаас үзэж болно);
  - (м) Томоохон хариуцлага хүлээх эсвэл болзошгүй өр төлбөр үүсгэх гэрээ хэлцэл байгуулах. Жишээлбэл; уг тайлангийн өдрийн дараа томоохон баталгаа гаргах; ба
  - (н) Зөвхөн тайлангийн өдрийн дараа гарч тохиолдсон үйл явдлуудын улмаас үүссэн томоохон зарга маргааныг эхлүүлэх.

### Хүчин төгөлдөр болох хугацаа

- 32. **Байгууллага нь энэхүү Стандартыг 2008 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2008 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.**
- 32А. **2010 оны 01 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Сайжруулалтууд*-аар 16-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2011 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө.**
- 32Б. **2015 оны 01 дүгээр сард гаргасан *УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-ийн үр дүнд 33-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш**

эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед УСНББОУС 33-ыг мөрдсөн бол уг нэмэлт өөрчлөлтийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.

32В. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд*-аар 31-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.

32Г. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 3, 4-р параграфуудыг хасаж, 15, 21-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.

32Д. 2017 оны 01 дүгээр сард гаргасан *УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл*-ийн үр дүнд 31-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.

33. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

## **УСНББОУС 14 (2001)-ээс татгалзах**

34. Энэ Стандарт нь 2001 онд гаргасан УСНББОУС 14, *Тайлангийн Өдрийн Дараах Үйл Явдал*-ыг орлоно.

**Хавсралт**

**Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт**

[Хассан]

## Дүгнэлтийн Үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 14-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### **НББОУС3-ийн Ерөнхий Сайжруулалтын Төсөл 2003-ын үр дүнд УСНББОУС 14-ийг хянан засварласан.**

#### *Оршил*

- ДҮ1. УСНББОУС3-ийн СТОУС-тай нийцүүлэх хөтөлбөр нь УСНББОУС3-ийн ажлын хөтөлбөрийн чухал элемент юм. УСНББОУС3-ийн бодлого нь улсын секторын байгууллагуудад тохиромжтой тохиолдолд НББОУС3-өөс гаргасан СТОУС-тай аккруэл суурьт УСНББОУС-ыг нийцүүлэх явдал юм.
- ДҮ2. Улсын секторын хувьд гажих тусгай учир шалтгаан байхаас бусад тохиолдолд СТОУС-тай нийцүүлсэн, аккруэл суурьт УСНББОУС нь СТОУС-ын шаардлага, бүтэц, текстийг тэр хэвээр хадгална. СТОУС-ын шаардлага буюу нэр томъёо нь улсын секторт тохиромжгүй эсвэл улсын секторын хувьд зарим тодорхой шаардлагуудыг үлгэрчлэн харуулахын тулд нэмэлт тайлбар буюу жишээ оруулах шаардлагатай тохиолдолд адилтгах СТОУС-аас гаждаг. УСНББОУС-ууд ба тэдгээртэй адилтгах СТОУС-уудын хоорондох ялгаатай талуудыг УСНББОУС нэг бүрд тусган оруулсан *СТОУС-тай Харьцуулалт*-д тодорхойлсон.
- ДҮ3. 2002 оны 5 дугаар сард өөрийн Ерөнхий Сайжруулалтын Төслийн нэг хэсэг болгон НББОУС3 нь 13-н НББОУС<sup>1</sup>-д оруулахаар санал болгосон нэмэлт өөрчлөлтийн саналын төслийг гаргасан. НББОУС3-ийн Ерөнхий Сайжруулалтын Төслийн зорилго нь “Стандартуудын хүрээн дэх сонголтод олон хувилбарууд, илүүдэл зүйлс, зөрчилтэй заалтуудыг арилгах буюу бууруулах, нийцүүлэлтийн зарим асуудлуудыг шийдэх ба бусад сайжруулалтыг хийх”-д оршино. НББОУС-ын эцсийн хувилбарыг 2003 оны 12 дугаар сард гаргасан.
- ДҮ4. 2001 оны 12 дугаар сард гаргасан УСНББОУС 14 нь НББОУС 10, *Балансын Өдрийн Дараах Үйл Явдал* (1999 онд хянан засварласан)-д үндэслэсэн. НББОУС 10-ыг 2003 оны 12 дугаар сард дахин гаргасан. УСНББОУС3-ийн өмнөх байгууллага болох Улсын Секторын Хороо (УСХ)<sup>2</sup> нь 2003 оны 12 дугаар сард гаргасан, сайжруулсан НББОУС-тай тохиромжтой хэмжээгээр УСНББОУС-ыг нийцүүлэхийн тулд УСНББОУС-ыг сайжруулах төслийг 2003 оны эцсээр хэрэгжүүлж эхэлсэн.

---

<sup>1</sup> НББОУС3-ийн өмнөх байгууллага болох НББОУСХ-ноос НББОУС-ыг гаргасан. НББОУС3-өөс гаргасан стандартуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) гэж нэрлэдэг. СТОУС-ыг НББОУС3 нь СТОУС, НББОУС, Стандартын Тайлбаруудаас бүрдэнэ гэж тодорхойлсон. Зарим тохиолдолд НББОУС3 нь НББОУС-ыг сольж орлуулахгүй, харин нэмэлт өөрчлөлт оруулдаг бөгөөд ингэснээр хуучин НББОУС-ын дугаарлалт хэвээр үлддэг.

<sup>2</sup> ДНБХ-ны Зөвлөл нь УСХ-г стандарт тогтоох бие даасан зөвлөл болгохын тулд түүний бүрэн эрхийг 2004 оны 11 дүгээр сард өөрчилснөөр УСХ нь УСНББОУС3 болсон.

- ДҮ5. УСНББОУСЗ нь уг сайжруулсан НББОУС 10-ыг нягталж шалгаад ингэж хянан засварлах болсон НББОУСЗ-ийн учир шалтгаан болон хийсэн нэмэлт өөрчлөлттэй ерөнхийдөө санал нэгдсэн. (НББОУСЗ-ийн Дүгнэлтийн Үндэслэлийг энд дахин нийтлээгүй болно. НББОУСЗ-ийн *Цогц Захиалгын Үйлчилгээ*-гээр захиалагч нар нь [www.iasb.org](http://www.iasb.org) хаягаар орж, НББОУСЗ-ийн вэб сайтаас Дүгнэлтийн Үндэслэлийг үзэж болно). УСНББОУС нь адилтгах НББОУС-аас гажих тохиолдолд улсын секторын хувьд гажих тусгай учир шалтгааныг Дүгнэлтийн Үндэслэлд тайлбарладаг.
- ДҮ6. 2003 оны 12 дугаар сараас хойш гаргасан СТОУС-уудын үр дүнд НББОУС 10-д цаашид нэмэлт өөрчлөлт оруулсан. 2003 оны 12 дугаар сараас хойш гаргасан СТОУС-уудын үр дүн болох нэмэлт өөрчлөлтүүдийг УСНББОУС 14-д тусган оруулаагүй байна. Яагаад гэвэл, УСНББОУСЗ нь тэдгээр СТОУС-уудын шаардлагуудыг нягтлан шалгаж, улсын секторын байгууллагуудад мөрдөгдөх боломжит байдлын талаар өөрийн үзэл бодлыг хараахан илэрхийлээгүй байгаа юм.

**2008 онд гаргасан, НББОУСЗ-ийн СТОУС-ын Сайжруулалтууд-ын үр дүнд УСНББОУС 14-д хийсэн хянан засварлалт**

- ДҮ7. УСНББОУСЗ нь 2008 оны 5 дугаар сард НББОУСЗ-өөс гаргасан *СТОУС-ын Сайжруулалтууд*-д тусгасан, НББОУС 10-ын хянан засварлалтыг нягталж шалгаад уг Стандартыг хянан засварлах болсон НББОУСЗ-ийн учир шалтгаантай ерөнхийдөө санал нийлсэн. УСНББОУСЗ нь уг нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдөхгүй байх улсын секторын тусгай учир шалтгаан байхгүй гэж дүгнэсэн.

**УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд-ын Хэсэг III: “Санал гаргагчдын дэвшүүлсэн асуудлууд”-ын үр дүнд УСНББОУС 14-д хийсэн хянан засварлалт**

- ДҮ8. Санал гаргагчид нь борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба данснаас хасах бүлгийг УСНББОУС тууштай бус илэрхийлсэн гэж үзсэн. СТОУС 5, *Борлуулах Зорилгоор Эзэмшиж Буй Эргэлтийн Бус Хөрөнгө ба Зогсоосон Үйл Ажиллагаа* нь дараах учир шалтгааны улмаас зөвхөн зарим нөхцөл байдалд улсын секторт тохиромжтой байж болох юм гэж УСНББОУСЗ дүгнэсэн:
- (а) Шаардлагатай түвшний зөвшөөрлийн улмаас улсын секторт хөрөнгийн борлуулалтыг нэг жилийн дотор хийж чадахгүй байж болох юм. Энэ нь СТОУС 5-ын дагуу тусгах мэдээллийн хамааралтай ба тууштай байдалд эргэлзээ үүсгэдэг. Тухайлбал; борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийг СТОУС 5-ын дагуу элэгдүүлэхгүй гэдгийг УСНББОУСЗ онцлон тэмдэглэсэн. Хөрөнгийг урт хугацаанд элэгдүүлэхгүй байх нь тохиромжгүй гэж УСНББОУСЗ үзэж байна.
  - (б) Улсын секторт олон хөрөнгийг үнэгүй эсвэл нэрлэсэн төлбөртэйгээр шилжүүлэх буюу түгээн хуваарилах замаар данснаас хасдаг. СТОУС 5 нь бодит үнэ цэнээр хийх борлуулалтыг авч үздэг тул түүний

хэмжилт ба тодруулгын шаардлагууд нь ийм шилжүүлэлтийн хувьд холбогдох мэдээллээр хангадаггүй. Гэвч борлуулалтыг бодит үнэ цэнээр хийх санаа зорилготой байх тохиолдолд СТОУС 5-ын хэмжилт ба тодруулгын шаардлагууд нь тохиромжтой байж болно гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрдөг.

- (в) Улсын сектор дахь зогсоосон олон үйл ажиллагаа нь үнэгүй эсвэл нэрлэсэн төлбөртэйгээр өмнө үзүүлсэн үйлчилгээ байдаг. СТОУС 5 нь данснаас хасах эсвэл борлуулах зорилгоор эзэмшиж буй гэж дахин ангилахаас өмнө мөнгө бий болгогч нэгжүүд буюу мөнгө бий болгогч нэгжүүдийн бүлэг байсан, тийм зогсоосон үйл ажиллагааг авч үздэг тул түүний тодруулгын шаардлагууд нь улсын секторын зогсоосон үйл ажиллагааны хувьд холбогдох мэдээллээр хангадаггүй байж болох юм. Гэвч зогсоосон үйл ажиллагаа нь өмнө нь мөнгө бий болгогч нэгжүүд буюу мөнгө бий болгогч нэгжүүдийн нэг болон хэд хэдэн бүлгүүд байсан бол СТОУС 5-ын тодруулгын шаардлагууд тохиромжтой байж болно гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрдөг.

СТОУС 5 нь зөвхөн цөөн хязгаарлагдмал нөхцөл байдалд улсын секторт тохиромжтой гэж УСНББОУСЗ дүгнэсэн учраас борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагааг авч үзэх олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн стандартуудын талаархи УСНББОУС дахь хэллэг лавлагааг хасахыг УСНББОУСЗ зөвшөөрсөн. Ийм хэллэг лавлагааг хасалгүй үлдээх нь СТОУС 5-ын шаардлагууд тохиромжгүй байж болох нөхцөл байдалд байгууллагууд түүний шаардлагуудыг даган мөрдөхөд хүргэнэ гэж УСНББОУСЗ санаа зовж байсан. УСНББОУС-уудад тусгайлан авч үзээгүй ажил гүйлгээний хувьд нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох заавар удирдамжаар УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого*, *Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* хангана гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Тохиромжтой гэж тухайн байгууллага үзсэн тохиолдолд СТОУС 5-тай нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тэдгээр байгууллагууд баримтлахыг ийм заавар удирдамжаар зөвшөөрсөн байдаг.

**2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУСЗ-ийн УСНББОУС-ЫН Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 14-д хийсэн хянан засварлалт**

ДҮ9. УСНББОУСЗ нь 2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ЫН Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (а) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба

## ТАЙЛАНГИЙН ӨДРИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын зэрэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р* параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.



## НББОУС 10-ТАЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 14, *Тайлангийн Өдрийн Дараах Үйл Явдал*-ыг НББОУС 10, *Балансын Өдрийн Дараах Үйл Явдал* (2003 онд хянан засварласан)-аас үндсэндээ бэлтгэсэн бөгөөд 2008 оны 5 дугаар сард гаргасан, *СТОУС-ын Сайжруулалтууд*-ын нэг хэсэг байдлаар НББОУС 10-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг үүнд тусгасан болно. УСНББОУС 14 ба НББОУС 10-ын хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- Тасралтгүй байх төсөөлөл цаашид тохиромжгүй болсон тохиолдолд санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд энэхүү өөрчлөлтийн үзүүлэх үр нөлөөг тодорхойлохдоо шүүн тунгаалт хийх шаардлагатай гэдгийг УСНББОУС 14-д тэмдэглэсэн.
- УСНББОУС 14 нь нийтэд гаргах зөвшөөрлийн өдрийг тодорхойлох талаархи нэмэлт тайлбарыг агуулсан байдаг.
- УСНББОУС 14 нь зарим тохиолдолд НББОУС 10-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь УСНББОУС 14 дэх “цэвэр хөрөнгө/өмч” ба “тайлангийн өдөр” гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. НББОУС 10 дахь адилтгах нэр томъёо нь “өмч” ба “балансын өдөр” юм.
- НББОУС 10-ын хувьд “орлого” /revenue/ нэр томъёоноос илүү өргөн утгатай байдаг “орлого” /income/ нэр томъёог УСНББОУС 14-д ашигладаггүй.
- УСНББОУС 14 нь “тайлангийн өдөр”-ийн талаархи тодорхойлолтыг агуулсан байдаг, харин НББОУС 10-д “балансын өдөр” гэсэн тодорхойлолт байдаггүй.

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) 15, Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга ба Толилуулга-ыг УСНББОУС 28, Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга; УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт; УСНББОУС 30, Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга-гаар орлуулсан. Эдгээр Стандартуудыг 2013 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Үүний үр дүнд УСНББОУС 15-ыг цаашид мөрдөхгүй бөгөөд хүчингүй болгосон.

## УСНББОУС 16–ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗОРИУЛАЛТТАЙ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) 40, *Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө* (2003 онд хянан засварласан)-өөс үндсэндээ бэлтгэсэн болно. НББОУС 40-өөс авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон ЕС4М 6ХН, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)  
Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.

## УСНББОУС 16-ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗОРИУЛАЛТТАЙ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

### УСНББОУС-ЫН ТҮҮХ

Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

УСНББОУС 16, Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө-ийг 2001 оны 12 дугаар сард гаргасан.

2006 оны 12 дугаар сард УСНББОУСЗ нь хянан засварласан УСНББОУС 16-г гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 16-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл (2017 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2011-ийн Сайжруулалтууд (2011 оны 10 дугаар сард гаргасан)
- УСНББОУС-ын Сайжруулалтууд (2010 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 27, Хөдөө Аж Ахуй (2009 оны 12 дугаар сард гаргасан)

### УСНББОУС 16-гийн нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт

Өөрчлөгдсөн параграф	Хэрхэн өөрчилсөн	Юугаар өөрчилсөн
Танилцуулга хэсэг	Хассан	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
3	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
4	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
6	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 27, 2009 оны 12-р сар УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
9	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
12	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗОРИУЛАЛТТАЙ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

13	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар
18А	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
20	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
29	Хассан	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар
40	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
57	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар
59	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар
62	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар
62А	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар
62Б	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар
63	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар
66	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар
87	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
90	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
91	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
92	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
93	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
94	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
95	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
96	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
98	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
99	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
101А	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар
101Б	Шинэ	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
101В	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
101Г	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
101Д	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
102	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
Үлгэрчилсэн шийдвэрийн мод	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар

2006 оны 12 дугаар сар

**УСНББОУС 16–ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗОРИУЛАЛТТАЙ ҮЛ  
ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ**

**АГУУЛГА**

	Параграф
Зорилго	1
Цар хүрээ	2-6
Тодорхойлолт	7-19
Үйл ажиллагааны түрээсийн дагуу түрээслэгчийн эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийн хувь оролцоо	8
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	9-19
Хүлээн зөвшөөрөлт	20-25
Хүлээн зөвшөөрөлтийн үеийн хэмжилт	26-38
Хүлээн зөвшөөрөлтийн дараах хэмжилт	39-65
Нягтлан бодох бүртгэлийн бодлого	39-41
Бодит үнэ цэнийн загвар	42-64
Бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй байдал	62-64
Өртгийн загвар	65
Шилжүүлэлт	66-76
Данснаас хасалт	77-84
Тодруулга	85-90
Бодит үнэ цэнийн загвар ба өртгийн загвар	85-90
Бодит үнэ цэнийн загвар	87-89
Өртгийн загвар	90
Шилжилтийн нөхцөл	91-100
Аккруэл нягтлан бодох бүртгэлийг анх удаа мөрдөх	91-93
Бодит үнэ цэнийн загвар	94-97
Өртгийн загвар	98-100
Хүчин төгөлдөр болох хугацаа	101-102
УСНББОУС 16 (2001)-аас татгалзах	103
Дүгнэлтийн үндэслэл	
Үлгэрчилсэн шийдвэрийн мод	
НББОУС 40-тэй харьцуулалт	

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗОРИУЛАЛТТАЙ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 16, *Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө*-ийг 1-103-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 16-г түүний зорилгын агуулга, Дүгнэлтийн Үндэслэл, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

1. Энэ Стандартын зорилго нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн арга хандлага болон холбогдох тодруулгын шаардлагыг тодорхойлоход оршино.

## Цар хүрээ

2. **Нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг тайлагнахдаа энэ Стандартыг мөрдөнө.**
3. [Хассан]
4. [Хассан]
5. Энэ Стандартыг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн тайлагналд, үүн дотроо (а) санхүүгийн түрээс гэж тайлагнадаг түрээсийн дагуу эзэмшиж буй хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хувь оролцооны түрээслэгчийн санхүүгийн тайлан дахь хэмжилт, ба (б) үйл ажиллагааны түрээсийн дагуу түрээслэгчид ашиглуулж буй хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн түрээслүүлэгчийн санхүүгийн тайлан дахь хэмжилтэнд мөрдөнө. УСНББОУС 13, Түрээс-т тусгагдсан асуудлуудыг, үүн дотроо дараах зүйлсийг энэ Стандартаар авч үзэхгүй:
  - (а) Санхүүгийн түрээс эсвэл үйл ажиллагааны түрээс гэсэн түрээсийн ангилал;
  - (б) Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөөс үүссэн түрээсийн орлогын хүлээн зөвшөөрөлт (УСНББОУС 9, *Арилжааны Ажил Гүйлгээний Орлого*-ыг бас үзнэ үү);
  - (в) Үйл ажиллагааны түрээс гэж тайлагнадаг түрээсийн дагуу эзэмшиж буй хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хувь оролцооны түрээслэгчийн санхүүгийн тайлан дахь хэмжилт;
  - (г) Санхүүгийн түрээст түрээслүүлэгчийн оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хувьд түүний санхүүгийн тайлан дахь хэмжилт;
  - (д) Борлуулах ба буцаан түрээслэх ажил гүйлгээний тайлагнал;
  - (е) Санхүүгийн түрээс ба үйл ажиллагааны түрээсийн талаархи тодруулга.
6. Энэ Стандартыг дараах зүйлсэд мөрдөхгүй:
  - (а) Хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой биологийн хөрөнгө (УСНББОУС 27, *Хөдөө Аж Ахуй*, УСНББОУС 17, *Үндсэн Хөрөнгө*-ийг үзнэ үү); болон



- (б) Газрын тос, байгалийн хий болон тэдгээртэй ижил төсөөтэй үл нөхөн сэргээгдэх нөөц гэх мэт ашигт малтмалын эрх ба ашигт малтмалын нөөц.

## Тодорхойлолт

7. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

Дансны үнэ гэдэг нь (энэ Стандартын зорилгын хувьд) хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрдөг дүн юм.

Өртөг гэдэг нь хөрөнгийг олж эзэмшихийн тулд түүнийг худалдан авах эсвэл барьж байгуулах хугацаанд төлсөн мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийн дүн буюу өгсөн бусад зүйлсийн бодит үнэ цэнэ юм.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэдэг нь доор дурдсан зорилгоор биш, харин түрээсийн орлогоор эсвэл капиталын үнийн өсөлтөөр, эсвэл энэ хоёрын аль алианаар ашиг олохын тулд эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгө (газар эсвэл барилга буюу барилгын нэг хэсэг, эсвэл газар, барилгын аль аль нь) юм:

- (а) Бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл буюу нийлүүлэлтэнд эсвэл захиргаа удирдлагын зорилгоор ашиглах; эсвэл  
(б) Хэвийн үйл ажиллагааны явцад худалдан борлуулах.

Эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгө гэдэг нь бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл буюу нийлүүлэлтэнд эсвэл захиргаа удирдлагын зорилгоор ашиглахын тулд эзэмшиж буй (эзний эсвэл санхүүгийн түрээсийн дагуу түрээслэгчийн эзэмшиж буй) үл хөдлөх хөрөнгө юм.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д дахин нийтэлсэн болно.

Үйл ажиллагааны түрээсийн дагуу түрээслэгчийн эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийн хувь оролцоо

8. Үйл ажиллагааны түрээсийн дагуу түрээслэгчийн эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийн хувь оролцоог зөвхөн дараах тохиолдолд хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэж ангилан тайлагнаж болно: (а) уг үл хөдлөх хөрөнгө нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн тодорхойлолтыг ямар нэг байдлаар хангах, (б) түрээслэгч нь тэрхүү хүлээн зөвшөөрсөн хөрөнгийн хувьд 42-64-р параграфт заасан бодит үнэ цэнийн загварыг ашигладаг байх. Ангиллын энэхүү хувилбарыг үл хөдлөх хөрөнгө нэг бүрээр ашиглаж болох юм. Гэвч үйл ажиллагааны

түрээсийн дагуу эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийн ийм нэг хувь оролцооны хувьд ангиллын энэхүү хувилбарыг сонгосон тохиолдолд хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэж ангилсан бүх үл хөдлөх хөрөнгийг бодит үнэ цэнийн загвар ашигласнаар тайлагнана. Ангиллын энэ хувилбарыг сонгосон тохиолдолд ингэж ангилсан аливаа хувь оролцоог 85-89-р параграфтаар шаардсан тодруулгад тусган оруулна.

### Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

9. Улсын секторын байгууллагууд нь түрээсийн орлогоор болон капиталын үнийн өсөлтөөр ашиг олохын тулд үл хөдлөх хөрөнгийг эзэмшиж болох олон нөхцөл байдал байдаг. Жишээлбэл; засгийн газрын үл хөдлөх хөрөнгийн багцыг худалдаа арилжааны сууриар удирдан зохицуулахын тулд улсын секторын байгууллагыг үүсгэн байгуулж болох юм. Энэ тохиолдолд уг байгууллагын хэвийн үйл ажиллагааны явцад дахин борлуулахаар эзэмшиж байгаагаас бусад, үл хөдлөх хөрөнгө нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн тодорхойлолтыг хангадаг. Улсын секторын бусад байгууллагууд нь түрээсийн буюу капиталын үнийн өсөлтийн зорилгоор үл хөдлөх хөрөнгийг бас эзэмшиж болох бөгөөд өөрийн бусад үйл ажиллагааг (үйлчилгээ үзүүлэх) санхүүжүүлэхийн тулд түүнээс бий болсон мөнгийг ашиглаж болох юм. Жишээлбэл; их сургууль эсвэл орон нутгийн засаг захиргаа нь бүтээгдэхүүн үйлдвэрлэх буюу үйлчилгээ үзүүлэх биш, харин мөнгө санг бий болгохын тулд гаднын талуудад арилжааны сууриар түрээслэх зорилгоор барилгыг өмчилдөг байж болно. Ийм үл хөдлөх хөрөнгө нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн тодорхойлолтыг бас хангана.
10. Түрээсийн орлогоор эсвэл капиталын үнийн өсөлтөөр, эсвэл энэ хоёрын аль алианаар ашиг олохын тулд хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг эзэмшдэг. Иймээс хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө нь тухайн байгууллагын эзэмшиж буй бусад хөрөнгөөс бүрэн хамааралгүй байдлаар мөнгөн гүйлгээг бий болгодог. Энэ шинж нь улсын секторын байгууллагуудын хянаж буй бусад үл хөдлөх хөрөнгөөс, үүн дотроо эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгөөс тэрхүү хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг ялган тодорхойлж өгдөг. Бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл буюу нийлүүлэлт (эсвэл үл хөдлөх хөрөнгийг захиргаа удирдлагын зорилгоор ашиглалт) нь мөн мөнгөн гүйлгээг бий болгодог. Тухайлбал; улсын секторын байгууллагууд нь өртгийг бүрэн буюу хэсэгчлэн нөхсөний хариуд тэдгээр хүлээн авагч нарыг бараа, үйлчилгээгээр хангахын тулд барилгыг ашиглаж болох юм. Гэвч бараа, үйлчилгээний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэхийн тулд барилгыг эзэмшдэг бөгөөд мөнгөн гүйлгээг зөвхөн тухайн барилгад төдийгүй уг үйлдвэрлэл, хангамжийн процессод ашигласан бусад хөрөнгөнд бас хамааруулж болох юм. Эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгийн хувьд УСНББОУС 17, *Үндсэн Хөрөнгө*-ийг мөрдөнө.
11. Улсын секторын зарим эрх зүйн орчинд тухайн байгууллага нь өөр байгууллагын хууль ёсоор өмчилдөг хөрөнгийг хянаж болох захиргааны

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗОРИУЛАЛТТАЙ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

тодорхой зохицуулалттай байдаг. Жишээлбэл; засгийн газрын хэлтэс нь хууль ёсоор Төр өмчилдөг зарим барилгыг хянаж, тайлагнадаг байж болно. Ийм тохиолдолд эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгө гэсэн хэллэг нь тухайн байгууллага ашигладаг бөгөөд өөрийн санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрсөн үл хөдлөх хөрөнгийг илэрхийлдэг.

12. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн жишээг доор дурдав:

- (а) Хэвийн үйл ажиллагааны явцад богино хугацаанд борлуулах зориулалтаар бус, харин урт хугацаанд капиталын үнэ өсгөх зорилгоор эзэмшиж буй газар. Жишээлбэл; ирээдүйд ашигтай үед нь борлуулж болох бөгөөд капиталын үнэ өсгөх зорилгоор эмнэлгийн эзэмшиж буй газар.
- (б) Одоогоор тодорхой бус байгаа ирээдүйн ашиглалтанд зориулан эзэмшиж буй газар. (Хэрэв байгууллага нь газрыг эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгө байдлаар, үүн дотроо одоогийн болон ирээдүйн үеийнхэнд зориулан үндэсний цэцэрлэгт хүрээлэн гэх мэт үйлчилгээ үзүүлэхийн тулд ашиглана эсвэл хэвийн үйл ажиллагааны явцад богино хугацаанд борлуулах зорилгоор ашиглана гэж тодорхойлоогүй бол уг газрыг капиталын үнэ өсгөх зорилгоор эзэмшиж байгаа гэж үзнэ).
- (в) Байгууллагын өмчилдөг (буюу санхүүгийн түрээсийн дагуу уг байгууллагын эзэмшиж буй) бөгөөд нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны түрээсийн дагуу арилжааны сууриар түрээслүүлсэн барилга. Жишээлбэл; их сургууль нь гаднын талуудад арилжааны сууриар түрээслүүлэх барилгыг өмчилдөг байж болох юм.
- (г) Ашиглаагүй, сул чөлөөтэй байгаа боловч нэг буюу хэд хэдэн үйл ажиллагааны түрээсийн дагуу гаднын талуудад арилжааны сууриар түрээслүүлэх зорилгоор эзэмшиж буй барилга.
- (д) Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө байдлаар ирээдүйд ашиглахын тулд барьж байгуулж эсвэл хөгжүүлж буй үл хөдлөх хөрөнгө.

13. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө биш, иймээс энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй зүйлсийн жишээг доор харуулав:

- (а) Хэвийн үйл ажиллагааны явцад борлуулах эсвэл ийм борлуулалтанд бэлтгэн барьж байгуулах буюу хөгжүүлэх явцад борлуулах зорилгоор эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгө (УСНББОУС 12, *Бараа Материал*-ыг үзнэ үү). Жишээлбэл; хотын захиргаа нь үл хөдлөх хөрөнгийг худалдан авах ба борлуулснаар үнийн зөрүүгээс байнга орлого олдог байж болно. Энэ тохиолдолд ойрын ирээдүйд борлуулах эсвэл хөгжүүлэлт хийж, буцаан борлуулах эцсийн зорилготойгоор эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийг бараа материал гэж ангилна. Орон сууцны газар нь хүн ам зүйн өөрчлөлтийн үр дүнд орон сууц хэлбэрийн хөрөнгийн зарим хэсгийг өөрийн хэвийн үйл

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗОРИУЛАЛТТАЙ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

ажиллагааны явцад байнга борлуулдаг байж болох бөгөөд энэ тохиолдолд борлуулах зорилгоор эзэмшиж буй аливаа орон сууц хэлбэрийн хөрөнгийг бараа материал гэж ангилна.

- (б) Гуравдагч талын нэрийн өмнөөс барьж байгуулж эсвэл хөгжүүлж буй үл хөдлөх хөрөнгө. Жишээлбэл; үл хөдлөх хөрөнгө болон үйлчилгээний хэлтэс нь өөрийн засгийн газрын хувьд гаднын байх байгууллагуудтай барилгын ажлын гэрээ байгуулж болох юм (УСНББОУС 11, *Барилгын Гэрээ*-г үзнэ үү).
  - (в) Эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгө (УСНББОУС 17-г үзнэ үү). Бусад зүйлсээс гадна үүнд: эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгө байдлаар ирээдүйд ашиглахын тулд эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгө, ирээдүйд хөгжүүлэх ба эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгө байдлаар дараа нь ашиглахын тулд эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгө, цэргийн албан хаагчдын орон сууц гэх мэт ажилтнуудын ашиглаж буй үл хөдлөх хөрөнгө (ажилтнууд нь түрээсийн төлбөрийг зах зээлийн ханшаар төлж буй эсэхээс үл хамаарна), данснаас хасахаар хүлээгдэж буй эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгө хамаарна.
  - (г) [Хассан]
  - (д) Санхүүгийн түрээсийн дагуу бусад байгууллагад түрээслүүлсэн үл хөдлөх хөрөнгө.
  - (е) Нийгмийн үйлчилгээ үзүүлэхийн тулд эзэмшиж байгаа бөгөөд мөн мөнгөн орлогын гүйлгээ бий болгодог үл хөдлөх хөрөнгө. Жишээлбэл; орон сууцны газар нь бага орлоготой айл өрхүүдийг зах зээлийн түвшнээс бага үнээр орон сууцаар хангахын тулд орон сууц хэлбэрийн томоохон хөрөнгийг эзэмшдэг байж болно. Энэ тохиолдолд түрээсийн орлого эсвэл капиталын үнийн өсөлтийн биш, харин орон сууцаар хангах зорилгоор уг үл хөдлөх хөрөнгийг эзэмшиж байгаа бөгөөд олсон түрээсийн орлого нь тэрхүү үл хөдлөх хөрөнгийг эзэмшиж буй зорилгын хувьд дагалдах шинжтэй байна. Ийм үл хөдлөх хөрөнгийг “хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө” гэж үзэхгүй бөгөөд УСНББОУС 17-гийн дагуу тайлагнана.
  - (ж) Стратегийн зорилгоор эзэмшиж байгаа бөгөөд УСНББОУС 17-гийн дагуу тайлагнах үл хөдлөх хөрөнгө.
14. Олон улс оронд улсын секторын байгууллагууд нь түрээсийн орлого буюу капиталын үнийн өсөлтөөр ашиг олох биш, харин үйлчилгээ үзүүлэх зорилгыг биелүүлэхийн тулд үл хөдлөх хөрөнгийг эзэмшдэг. Ийм тохиолдолд уг үл хөдлөх хөрөнгө нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн тодорхойлолтыг хангадаггүй. Хэдийгээр улсын секторын байгууллага нь түрээсийн орлого буюу капиталын үнийн өсөлтөөр ашиг олохын тулд үл хөдлөх хөрөнгийг эзэмшдэггүй боловч энэ Стандартыг мөрдөх боломжтой байдаг. Зарим тохиолдолд улсын секторын байгууллагууд нь (а) үйлчилгээ үзүүлэх биш, харин түрээсийн орлогоор эсвэл капиталын үнийн өсөлтөөр ашиг олохын тулд эзэмшиж буй хэсэг, ба (б) бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл буюу

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗОРИУЛАЛТТАЙ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

нийлүүлэлтэнд, эсвэл удирдлагын зорилгоор ашиглахын тулд эзэмшиж буй хэсгээс бүрдсэн үл хөдлөх хөрөнгийг эзэмшдэг. Жишээлбэл; эмнэлэг буюу их сургууль нь үл хөдлөх хөрөнгийг өмчлөх бөгөөд түүний зарим хэсгийг захиргаа удирдлагын зорилгоор ашигладаг, нөгөө нэг хэсгийг орон сууц байдлаар арилжааны сууриар түрээслэдэг байж болно. Хэрэв эдгээр хэсгүүдийг тусад нь борлуулж (эсвэл санхүүгийн түрээсийн дагуу тусад нь түрээслүүлж) болохоор байвал байгууллага нь тэдгээр хэсгүүдийг тусдаа тайлагнана. Хэрэв эдгээр хэсгүүдийг тусад нь борлуулах боломжгүй бол уг үл хөдлөх хөрөнгийн өчүүхэн бага хэсгийг бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл буюу нийлүүлэлтэнд, эсвэл удирдлагын зорилгоор ашиглахын тулд эзэмшиж байх зөвхөн тийм тохиолдолд тухайн үл хөдлөх хөрөнгө нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө болно.

15. Зарим тохиолдолд байгууллага нь өөрийн эзэмшдэг үл хөдлөх хөрөнгийг ашиглагч нарт дагалдах үйлчилгээг үзүүлдэг. Хэрэв үйлчилгээ нь бүхэлдээ уг арга хэмжээний хувьд мэдэгдэхүйц нөлөөтэй биш бол байгууллага нь ийм үл хөдлөх хөрөнгийг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэж үзнэ. Жишээлбэл; засгийн газрын агентлаг нь (а) зөвхөн түрээсийн зорилгоор эзэмшдэг бөгөөд арилжааны сууриар түрээслэдэг оффисын барилгыг өмчилдөг байх, (б) тухайн барилгыг ашиглаж буй түрээслэгч нарт мөн харуул хамгаалалтын болон засвар үйлчилгээ үзүүлдэг байх.
16. Өөр зарим тохиолдолд тухайн үзүүлэх үйлчилгээ нь мэдэгдэхүйц нөлөөтэй байдаг. Жишээлбэл; засгийн газар нь өөрийн үл хөдлөх хөрөнгийн менежментийн ерөнхий агентлагаар дамжуулан удирддаг зочид буудал эсвэл дотуур байрыг өмчилдөг байж болно. Зочдод үзүүлэх үйлчилгээ нь бүхэлдээ уг арга хэмжээний хувьд мэдэгдэхүйц нөлөөтэй байна. Иймээс эзэн-удирддаг зочид буудал буюу дотуур байр нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө биш, харин эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгө юм.
17. Туслах үйлчилгээ нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн шалгуурыг тухайн үл хөдлөх хөрөнгө хангахгүй болоход хүргэх тийм мэдэгдэхүйц нөлөөтэй эсэхийг тодорхойлоход төвөгтэй байж болох юм. Жишээлбэл; зочид буудлын өмчлөгч болох засгийн газар буюу засгийн газрын агентлаг нь зарим үүрэг хариуцлагаа менежментийн гэрээний дагуу гуравдагч талд шилжүүлж болно. Ийм менежментийн гэрээний нөхцөл нь өргөн хүрээтэй, янз бүр байдаг. Уг хамрах хүрээний нэг туйлын тохиолдолд засгийн газар буюу засгийн газрын агентлаг нь үндсэндээ идэвхигүй хөрөнгө оруулагчийн байр суурьтай байж болно. Харин нөгөө туйлын тохиолдолд засгийн газар буюу засгийн газрын агентлаг нь тухайн зочид буудлын үйл ажиллагаагаар бий болох мөнгөн гүйлгээний хэлбэлзэл, өөрчлөлтийн талаархи мэдэгдэхүйц эрсдлийг өөрөө хүлээж, зөвхөн өдөр тутмын үүрэг ажиллагааг аутсорсингоор гүйцэтгүүлж болох юм.
18. Үл хөдлөх хөрөнгө нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн шалгуурыг хангах эсэхийг тодорхойлохын тулд шүүн тунгаалт

хийх шаардлагатай байдаг. Байгууллага нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн тодорхойлолт болон 9-17-р параграфт заасан холбогдох заавар удирдамжийн дагуу шүүн тунгаалтыг тууштай хийхийн тулд шалгуурыг боловсруулдаг. 86(в) параграф нь ангиллыг тогтооход хүндрэлтэй байх үед тухайн шалгуураа тодруулахыг байгууллагаас шаарддаг.

- 18А Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн худалдан авалт нь нэг хөрөнгийн буюу хөрөнгүүдийн бүлгийн худалдан авалт эсвэл УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийн цар хүрээнд хамаарах улсын секторын нэгдэл эсэхийг тодорхойлохын тулд мөн шүүн тунгаалт хийх шаардлагатай байдаг. Улсын секторын нэгдэл мөн эсэхийг тодорхойлохын тулд УСНББОУС 40-ийг лавлагаа болговол зохино. Уг үл хөдлөх хөрөнгө нь эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгө эсвэл хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, үл хөдлөх хөрөнгийн худалдан авалт нь УСНББОУС 40-д тодорхойлсон улсын секторын нэгдэл мөн эсэхээс үл хамааран энэ Стандартын 9-18-р параграф дахь хэлэлцүүлгийг харгалзан үзнэ. Тухайн ажил гүйлгээ УСНББОУС 40-д заасан улсын секторын нэгдлийн тодорхойлолтыг хангах ба энэ Стандартад заасанчлан, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөнд хамаарах эсэхийг тодорхойлох нь энэхүү хоёр Стандартын аль алины тусдаа мөрдөлт, хэрэглээг шаардах юм.
19. Зарим тохиолдолд байгууллага нь түүнд өөрт нь хяналт тавигч байгууллага эсвэл түүний хяналтанд буй байгууллагад түрээслүүлсэн ба тэдэнд ашиглуулдаг үл хөдлөх хөрөнгийг өмчилдөг. Ийм үл хөдлөх хөрөнгө нь тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын зүгээс авч үзвэл эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгө тул энэ нь нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн шалгуурыг хангахгүй юм. Харин үл хөдлөх хөрөнгийг өмчилж буй тухайн байгууллагын зүгээс авч үзэхэд, уг үл хөдлөх хөрөнгө нь хэрэв 7-р параграфт заасан тодорхойлолтыг хангаж байвал хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө болно. Иймээс тухайн түрээслүүлэгч нь уг үл хөдлөх хөрөнгийг өөрийн бие даасан санхүүгийн тайландаа хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэж тайлагнана. Засгийн газар нь засгийн газрын оффисын барилгыг удирдан зохицуулах үл хөдлөх хөрөнгийн менежментийн байгууллага үүсгэн байгуулсан тохиолдолд ийм нөхцөл байдал үүсэж болох юм. Барилгыг засгийн газрын бусад байгууллагуудад арилжааны сууриар түрээслүүлдэг. Үл хөдлөх хөрөнгийн менежментийн байгууллагын санхүүгийн тайланд уг үл хөдлөх хөрөнгийг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэж тайлагнадаг. Гэвч засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланд уг үл хөдлөх хөрөнгийг УСНББОУС 17-гийн дагуу үндсэн хөрөнгө гэж тайлагнана.

## **Хүлээн зөвшөөрөлт**

20. **Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг зөвхөн дараах тохиолдолд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө:**

- (а) **Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь тухайн байгууллагад орох нилээд магадлалтай байх; ба**
- (б) **Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн өртөг буюу бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадах.<sup>1</sup>**

21. Тухайн зүйл нь хүлээн зөвшөөрөлтийн эхний шалгуурыг хангах эсэхийг тодорхойлохдоо, байгууллага нь ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхид хамаарах магадлалын зэрэг хэмжээг тэрхүү анхны хүлээн зөвшөөрөлтийн үед бэлэн боломжтой байгаа нотолгоонд үндэслэн үнэлэх шаардлагатай байдаг. Тухайн байгууллагад ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи орох хангалттай магадлалын оршин байдал нь уг байгууллага тэрхүү хөрөнгөнд хамаарах урамшууллыг хүлээн авах ба холбогдох эрсдлийг хүлээх баталгаатай байхыг шаарддаг. Эрсдэл ба урамшуулал нь тухайн байгууллагад зөвхөн шилжсэн тохиолдолд энэхүү баталгаа ихэвчлэн бэлэн боломжтой болдог. Үүнээс өмнө, уг хөрөнгө худалдан авах ажил гүйлгээг мэдэгдэхүйц торгууль төлөхгүйгээр ихэвчлэн цуцлах боломжтой байдаг бөгөөд иймээс хөрөнгийг хүлээн зөвшөөрдөггүй.
22. Хөрөнгийн худалдан авалтыг нотлох арилжааны ажил гүйлгээ нь түүний өртгийг тодорхойлдог ухаас хүлээн зөвшөөрөлтийн хоёр дахь шалгуурыг ихэвчлэн шууд хангагддаг. Энэ Стандартын 27-р параграфт тусгайлан заасанчлан, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг зарим нөхцөлд үнэгүй эсвэл нэрлэсэн үнээр худалдан авч болох юм. Ийм тохиолдолд өртөг нь тухайн худалдан авалтын өдрөөрх уг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнэ байдаг.
23. Энэхүү хүлээн зөвшөөрөлтийн зарчмын дагуу байгууллага нь өөрийн хөрөнгө оруулалтын зориулалттай бүх үл хөдлөх хөрөнгийн өртгийг тэдгээрийн гарсан үед үнэлнэ. Эдгээр өртөг зардал нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг анх худалдан авахад гарсан өртөг, түүнчлэн уг үл хөдлөх хөрөнгийг нэмэгдүүлэх, сольж орлуулах эсвэл засвар үйлчилгээ хийхэд дараа гарсан өртөг зардлаас бүрддэг.
24. 20-р параграфт заасан хүлээн зөвшөөрөлтийн зарчмын дагуу байгууллага нь тухайн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн өдөр тутмын засвар, үйлчилгээний зардлыг түүний дансны үнэд хүлээн зөвшөөрдөггүй. Харин эдгээр зардлыг гарсан үед нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Өдөр тутмын засвар, үйлчилгээний зардал нь ихэвчлэн хөдөлмөрийн болон хангамжийн зүйлсийн зардал байдаг боловч

---

<sup>1</sup> Найдвартай мэдээлэл нь материаллаг алдаа ба туйлшралаас ангид байх бөгөөд өөрийн илэрхийлэхээр зориулагдсан буюу илэрхийлнэ гэж үл үндэслэлтэйгээр хүлээж болох зүйлсийг үнэн зөв илэрхийлэхдээ хэрэглэгчдээс хамаардаг байж болох юм. Найдвартай байдлын тайлбарын талаархи шилжилтийн арга хандлагыг УСНББОУС 1-ийн ДҮ16-р параграфт авч хэлэлцсэн.

үүнд мөн жижиг сэлбэг хэрэгслийн өртөг хамаарч болох юм. Эдгээр зарлагын зорилгыг ихэвчлэн тухайн үл хөдлөх хөрөнгийн “засвар, үйлчилгээ”-ний зориулалттай гэж тодорхойлдог.

25. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн зарим хэсгийг сольж орлуулах замаар олж эзэмшсэн байж болно. Жишээлбэл; дотор хана нь анхны ханын сольж орлуулалт байж болох юм. Хэрэв хүлээн зөвшөөрөлтийн шалгуур хангагдаж байвал байгууллага нь одоо байгаа хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг сольж орлуулснаар нэмэгдэж буй хэсгийн өртгийг уг хүлээн зөвшөөрөлтийн зарчмын дагуу тэдгээр өртөг зардал гарсан цаг хугацаанд тухайн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дансны үнэд хүлээн зөвшөөрнө. Харин сольж орлуулан хасагдаж буй хэсгийн дансны үнийг энэхүү Стандартын үл хүлээн зөвшөөрөлтийн нөхцлүүдийн дагуу үл хүлээн зөвшөөрнө.

### **Хүлээн зөвшөөрөлтийн үеийн хэмжилт**

26. **Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг түүний өртгөөр анх хэмжинэ (ажил гүйлгээний зардлыг уг анхны хэмжилтэнд оруулна).**
27. **Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн тохиолдолд түүний өртгийг тухайн олж эзэмшсэн өдрөөрх бодит үнэ цэнээр хэмжинэ.**
28. Худалдан авсан хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн өртөг нь түүний худалдан авалтын үнэ ба шууд хамааруулж болох аливаа зарлагаас бүрдэнэ. Шууд хамааруулж болох зарлагад тухайлбал, хуулийн мэргэжлийн үйлчилгээний хөлс, үл хөдлөх хөрөнгийг шилжүүлсний татвар болон ажил гүйлгээний бусад зардал хамаарна.
29. [Хассан]
30. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн өртгийг дараах зүйлсээр нэмэгдүүлэхгүй:
- (a) Гарааны зардал (энэ нь удирдлагын төлөвлөсөн арга маягаар ажиллуулах боломжтой болгоход шаардлагатай тийм нөхцөл байдалд уг үл хөдлөх хөрөнгийг авчрахад зайлшгүй шаардлагатай байхаас бусад тохиолдолд);
  - (б) Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө нь түүний ашиглалтын төлөвлөсөн түвшинд хүрэхээс өмнө гарсан үйл ажиллагааны алдагдал; эсвэл
  - (в) Тухайн үл хөдлөх хөрөнгийг барьж байгуулах эсвэл хөгжүүлэх явцад гарсан хаягдал материал, хөдөлмөрийн зардал буюу бусад нөөцийн хэвийн бус дүн.



31. Хэрэв хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн төлбөрийг хойшлуулвал түүний өртөг нь мөнгөн үнэтэй адилтгах дүн байна. Энэхүү мөнгөн үнэтэй адилтгах дүн ба нийт төлбөрийн хоорондох зөрүүг тухайн зээлийн хугацааны туршид хүүний зардал гэж хүлээн зөвшөөрнө.
32. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшиж болно. Жишээлбэл; үндэсний засгийн газар нь оффисын зориулалттай илүүдэл барилгаа орон нутгийн засаг захиргааны байгууллагад үнэгүй шилжүүлж, түүнийг зах зээлийн түвшнээр түрээслүүлэхийг зөвшөөрсөн байж болно. Түүнчлэн, хөрөнгийг улсын орлого болгон хураах бүрэн эрхийг хэрэгжүүлж, арилжааны бус ажил гүйлгээгээр хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг олж эзэмшиж болно. Эдгээр нөхцөл байдалд тухайн үл хөдлөх хөрөнгийн өртөг нь түүнийг олж эзэмшсэн өдрөөрх бодит үнэ цэнэ байна.
33. Байгууллага нь өөрийн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг 27-р параграфын дагуу бодит үнэ цэнээр анх хүлээн зөвшөөрдөг тохиолдолд уг бодит үнэ цэнэ нь тухайн үл хөдлөх хөрөнгийн өртөг байна. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, байгууллага нь бодит үнэ цэнийн загвар (42-64-р параграф) эсвэл өртгийн загварын (65-р параграф) аль нэгийг мөрдөх шийдвэр гаргана.
34. **Түрээсийн дагуу эзэмшиж байгаа бөгөөд хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэж ангилсан, үл хөдлөх хөрөнгийн хувь оролцооны анхны өртөг нь УСНББОУС 13-ын 28-р параграфтаар санхүүгийн түрээсийн хувьд тодорхойлох дүнтэй адил байна. Өөрөөр хэлбэл, тухайн үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнэ ба түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийн аль багаар хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Дээр дурдсан параграфын дагуу мөн ижил дүнгээр өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.**
35. Түрээсийн хувьд төлсөн аливаа урамшууллыг энэхүү зорилгоор түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн нэг хэсэг гэж үзэх ба иймээс тухайн хөрөнгийн өртөгт оруулах боловч өр төлбөрт хамаарахгүй. Түрээсийн дагуу эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийн хувь оролцоог хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэж ангилдаг бол бодит үнэ цэнээр тайлагнах тухайн зүйл нь суурь үл хөдлөх хөрөнгө биш, харин тэрхүү хувь оролцоо байна. Үл хөдлөх хөрөнгийн хувь оролцооны бодит үнэ цэнийг тодорхойлох талаархи заавар удирдамжийг 42-61-р параграфт бодит үнэ цэнийн загварын хувьд тодорхойлсон. Анхны хүлээн зөвшөөрөлтийн зорилгоор бодит үнэ цэнийг өртөг болгон ашигладаг тохиолдолд энэхүү заавар удирдамж нь бодит үнэ цэнийг тодорхойлоход мөн хамаарах юм.
36. Мөнгөн зүйлийн бус хөрөнгө буюу хөрөнгүүдээр, эсвэл мөнгөн зүйлийн хөрөнгө ба мөнгөн зүйлийн бус хөрөнгийн аль алиныг оруулцуулсан солилцооны үр дүнд хөрөнгө оруулалтын зориулалттай нэг буюу хэд хэдэн үл хөдлөх хөрөнгийг олж эзэмшиж болох юм. Дараах хэлэлцүүлэг нь нэг мөнгөн зүйлийн бус хөрөнгийг өөр нэг мөнгөн зүйлийн бус хөрөнгөөр солилцох жишээнд хамаарах боловч өмнөх өгүүлбэрт дурдсан

бүх солилцооны хувьд үүнийг мөн баримтална. Ийм хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн өртгийг доор дурдсанаас бусад тохиолдолд бодит үнэ цэнээр хэмжинэ. Үүнд: (а) солилцооны ажил гүйлгээ нь худалдаа арилжааны шинж чанаргүй байх, (б) солилцоогоор хүлээн авсан болон өгсөн хөрөнгүүдийн аль алины бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй. Байгууллага нь өгч буй хөрөнгөө тэр даруй үл хүлээн зөвшөөрөх буюу данснаас хасах боломжгүй байлаа ч гэсэн тухайн олж эзэмшсэн хөрөнгөө дээр дурдсан байдлаар хэмжинэ. Хэрэв олж эзэмшсэн хөрөнгийг түүний бодит үнэ цэнээр хэмжээгүй бол тухайн хөрөнгийн өртгийг уг өгсөн хөрөнгийн дансны үнээр хэмжинэ.

37. Байгууллага нь тухайн ажил гүйлгээний үр дүнд түүний ирээдүйн мөнгөн гүйлгээ буюу үйлчилгээний чадавхи өөрчлөгдөхөөр хүлээгдэж буй хэмжээг харгалзах замаар уг солилцох ажил гүйлгээ нь худалдаа арилжааны шинж чанартай эсэхийг тодорхойлно. Солилцох ажил гүйлгээ нь дараах тохиолдолд худалдаа арилжааны шинж чанартай байна:

- (а) Хүлээн авсан хөрөнгийн мөнгөн гүйлгээ буюу үйлчилгээний чадавхийн төлөв байдал (эрсдэл, цаг хугацаа, дүн) нь шилжүүлэн өгсөн хөрөнгийн мөнгөн гүйлгээ буюу үйлчилгээний чадавхийн төлөв байдлаас өөр байх; эсвэл
- (б) Тухайн ажил гүйлгээгээр нөлөө үзүүлэх уг байгууллагын үйл ажиллагааны тодорхой нэг хэсгийн тэрхүү байгууллага дахь тусгайлсан үнэ цэнэ нь энэ солилцооны үр дүнд өөрчлөгдөх; ба
- (в) Дээрх (а) буюу (б)-д дурдсан зөрүү нь тухайн солилцсон хөрөнгүүдийн бодит үнэ цэнэтэй харьцуулахад мэдэгдэхүйц дүнтэй байх.

Солилцооны ажил гүйлгээ нь худалдаа арилжааны шинж чанартай эсэхийг тодорхойлох зорилгын хувьд тухайн ажил гүйлгээгээр нөлөө үзүүлэх уг байгууллагын үйл ажиллагааны тодорхой нэг хэсгийн тэрхүү байгууллага дахь тусгайлсан үнэ цэнэ нь хэрэв татвар төлдөг бол татварын дараах мөнгөн гүйлгээг илэрхийлсэн байна. Худалдаа арилжааны шинж чанартай эсэхийг тодорхойлох шинжилгээ нь тухайн байгууллага нарийвчилсан тооцоолол хийгээгүй байхад тодорхой, ойлгомжтой байж болох юм.

38. Зэрэгцүүлэгдэх зах зээлийн ажил гүйлгээ байхгүй хөрөнгийн бодит үнэ цэнийг дараах тохиолдолд найдвартай хэмжих боломжтой байдаг. Үүнд: (а) бодит үнэ цэнийн үлдэслэлтэй хэмжилтийн муж доторх хувьсан өөрчлөлт нь тухайн хөрөнгийн хувьд мэдэгдэхүйц дүнтэй биш байх, эсвэл (б) тухайн мужийн доторх өөр өөр тооцооллуудын магадлалыг үл үндэслэлтэйгээр үнэлэх ба бодит үнэ цэнийг хэмжих үед тэдгээрийг ашиглах боломжтой байх. Байгууллага нь солилцоогоор хүлээн авсан хөрөнгө эсвэл өгсөн хөрөнгийн аль алины бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадах тохиолдолд хүлээн авсан хөрөнгийн бодит үнэ цэнэ нь илүү тодорхой биш л бол тэрхүү хүлээн авсан хөрөнгийн өртгийг хэмжихийн тулд өгсөн хөрөнгийн бодит үнэ цэнийг ашиглана.

## Хүлээн зөвшөөрөлтийн дараах хэмжилт

### Нягтлан бодох бүртгэлийн бодлого

39. **43-р параграфт заасан гажих нөхцлөөс бусад тохиолдолд байгууллага нь 42-64-р параграфт дурдсан бодит үнэ цэнийн загвар эсвэл 65-р параграфт дурдсан өртгийн загварын аль нэгийг өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлого болгон сонгох бөгөөд тэрхүү бодлогоо хөрөнгө оруулалтын зориулалттай бүх үл хөдлөх хөрөнгөндөө мөрдөнө.**
40. Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрчилсөнөөр, санхүүгийн тайлан нь байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээнд ажил гүйлгээ, бусад үйл явдал буюу нөхцөл байдлын үзүүлэх үр нөлөөний талаар найдвартай ба илүү хамааралтай мэдээллээр хангахаар болох зөвхөн тийм тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сайн дураараа өөрчилнө гэж УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого*, *Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-д заасан байдаг. Бодит үнэ цэнийн загварыг өртгийн загвар болгох өөрчлөлт нь илүү хамааралтай толилуулгад хүргэх магадлал багатай юм.
41. Энэ Стандарт нь хэмжилт (хэрэв байгууллага нь бодит үнэ цэнийн загварыг ашигладаг бол) эсвэл тодруулга (хэрэв өртгийн загварыг ашигладаг бол)-ын аль нэг зорилгоор тухайн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийг тодорхойлохыг бүх байгууллагуудаас шаарддаг. Мэргэжлийн хүлээн зөвшөөрөгдсөн зохих үр чадвартай бөгөөд тэрхүү үнэлж буй хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн байршил, төрөл зүйлийн талаар сүүлийн үеийн туршлагатай, хараат бус үнэлгээчний хийсэн үнэлгээнд үндэслэн уг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийг хэмжихийг тухайн байгууллагаас заавал шаардахгүй боловч ингэж хэмжихийг сайшаан дэмжинэ.

### Бодит үнэ цэнийн загвар

42. **Бодит үнэ цэнийн загварыг сонгосон байгууллага нь анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, өөрийн хөрөнгө оруулалтын зориулалттай бүх үл хөдлөх хөрөнгийг 62-р параграфт зааснаас бусад тохиолдолд бодит үнэ цэнээр нь хэмжинэ.**
43. **Үйл ажиллагааны түрээсээр түрээслэгчийн эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийн хувь оролцоог 8-р параграфын дагуу хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэж ангилдаг тохиолдолд 39-р параграфт заасан сонголт хийх боломжгүй, харин бодит үнэ цэнийн загварыг мөрдөнө.**
44. **Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс бий болсон олз, гарзыг түүний үүссэн тухайн тайлант үеийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.**

45. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнэ нь зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хоорондох харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр уг үл хөдлөх хөрөнгийг арилжиж болох үнэ юм (7-р параграфыг үзнэ үү). Нийтлэг санхүүжилт, борлуулах ба буцаан түрээслэх хэлцэл, тусгай төлбөр буюу тухайн борлуулалттай холбоотой хэн нэгний эрх олгосон концесс гэх мэт тусгай нөхцөл, болзлоор өсгөж эсвэл бууруулж тооцсон үнэ нь бодит үнэ цэнэд хамаарахгүй.
46. Байгууллага нь борлуулалт буюу бусад данснаас хасалтаар гарч болох ажил гүйлгээний зардлын хувьд аливаа хасалт хийхгүйгээр бодит үнэ цэнийг тодорхойлно.
47. **Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнэ нь тухайн тайлангийн өдрөөрх зах зээлийн нөхцөл байдлыг тусгадаг.**
48. Бодит үнэ цэнэ нь тухайн өдрөөрх цаг хугацааны тусгайлсан үнэ цэнэ байна. Зах зээлийн нөхцөл байдал өөрчлөгдөж болох учраас хэрэв түүнийг өөр цаг хугацаанд тооцоолвол бодит үнэ цэнэ гэж тайлагнасан дүн нь буруу буюу тохиромжгүй байж болох юм. Бодит үнэ цэнийн тодорхойлолтын хувьд борлуулалтын гэрээний гүйцэтгэл ба арилжаа нь мөн нэгэн зэрэг хийгдэнэ гэж төсөөлдөг. Өөрөөр хэлбэл, арилжаа ба гэрээний гүйцэтгэл нь нэгэн зэрэг хийгдээгүй тохиолдолд тухайн арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хоорондох харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээний үнэд оруулж болох аливаа хувьсан өөрчлөлтгүй байх юм.
49. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнэ нь бусад зүйлсээс гадна одоогийн түрээсээс олох түрээсийн орлого, түүнчлэн одоогийн зах зээлийн нөхцөл байдалд ирээдүйн түрээсээс олох түрээсийн орлогын талаар тэдгээр зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын харгалзан үзэх зүйлсийг илэрхийлэх үлдэслэлтэй ба дэмжих таамаглалуудыг тусгадаг. Энэ нь тухайн үл хөдлөх хөрөнгийн хувьд хүлээгдэж болох аливаа мөнгөн зарлагын гүйлгээг (үүн дотроо, түрээсийн төлбөр болон бусад мөнгөн зарлагыг) мөн ижил төсөөтэй сууриар тусган илэрхийлдэг. Ийм зарим зарлагыг өр төлбөрт тусгадаг, харин зарим (жишээлбэл; болзошгүй түрээс гэх мэт үечилсэн төлбөрүүд) нь дараагийн тайлант өдөр хүртэл санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөхгүй зарлагуудтай холбоотой байдаг.
50. Түрээслэсэн үл хөдлөх хөрөнгийн хувь оролцооны өртгийг анх хүлээн зөвшөөрөх суурийг 34-р параграфт тусгайлан заасан. Хэрэв шаардлагатай бол уг түрээслэсэн үл хөдлөх хөрөнгийн хувь оролцоог бодит үнэ цэнээр дахин хэмжихийг 42-р параграфтаар шаарддаг. Зах зээлийн түвшнээр хэлцэн тохирсон түрээсийн хувьд, түрээслэсэн үл хөдлөх хөрөнгийн хувь оролцооны тухайн олж эзэмшсэн өдрөөрх бодит үнэ цэнээс бүх хүлээгдэж буй түрээсийн төлбөрүүдийг (үүн дотроо, хүлээн зөвшөөрсөн түрээсийн өр төлбөртэй холбоотой төлбөрүүдийг) хассан

цэвэр дүн нь тэг байна. Нягтлан бодох бүртгэлийн зорилгоор уг түрээслэсэн хөрөнгө ба өр төлбөрийг бодит үнэ цэнээр хэмжсэн эсвэл УСНББОУС 13-ын 28-р параграфын дагуу түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнээр хүлээн зөвшөөрсөн эсэхээс үл хамааран энэхүү бодит үнэ цэнэ өөрчлөгдөхгүй. Иймээс 34-р параграфын дагуу өртгөөр хэмждэг, уг түрээслэсэн хөрөнгийг 42-р параграфын дагуу бодит үнэ цэнээр дахин хэмжих нь тухайн бодит үнэ цэнийг өөр өөр хугацаанд хэмжсэнээс бусад тохиолдолд эхлээд ямар нэг олз эсвэл гарз үүсэхэд хүргэхгүй. Бодит үнэ цэнийн загварыг хэрэглэх сонголтыг анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа хийсэн бол ийм тохиолдол үүсэж болно.

51. Бодит үнэ цэнийн тодорхойлолтонд “зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талууд” гэж заасан. Энэ тохиолдолд “зохих мэдлэгтэй” гэдэг нь уг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн төрөл ба шинж чанар, түүний бодит болон боломжит ашиглалт, тухайн тайлангийн өдрөөрх зах зээлийн нөхцөл байдлын талаар тэрхүү арилжаанд оролцоход бэлэн байгаа худалдан авагч ба борлуулагчийн аль аль нь зохих мэдээллийг авсан гэсэн утгыг илэрхийлдэг. Арилжаанд оролцоход бэлэн худалдан авагч нь худалдан авах сэдэл урамшуулалттай боловч шахалт тулгалтанд ороогүй байна. Ийм худалдан авагч нь хэт шунан хүссэн ч байх ёсгүй, мөн түүнийг ямар ч үнээр хамаагүй худалдан авна гэж тодорхойлж ч болохгүй. Уг таамагласан худалдан авагч нь зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа худалдан авагч ба борлуулагч нараас бүрдэх зах зээлээр шаардах үнээс өндөр дүнг төлөхгүй юм.
52. Арилжаанд оролцоход бэлэн байгаа борлуулагч нь ямар ч хамаагүй үнээр борлуулахад бэлэн хэт шунан хүссэн ч биш, албадлага шахалтаар хийж буй борлуулагч ч биш бөгөөд дурын үнээр борлуулахад бэлэн байх эсвэл одоогийн зах зээлийн нөхцөл байдлыг үл үндэслэлтэйгээр харгалзаагүй үнээр борлуулахаар хүлээх ёсгүй. Арилжаанд оролцоход бэлэн байгаа борлуулагч нь зах зээлийн нөхцлийн дагуу олж болох хамгийн сайн үнээр тухайн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг борлуулах сэдэл урамшуулалттай байна. Арилжаанд оролцоход бэлэн байгаа борлуулагч нь түүний таамагласан өмчлөгч учраас тухайн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчийн бодит нөхцөл байдал нь энэхүү анхаарах зүйлсийн нэг хэсэг биш юм (жишээлбэл; арилжаанд оролцоход бэлэн байгаа борлуулагч нь тухайн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчийн татварын бодит нөхцөл байдлыг харгалзан үзэхгүй).
53. Бодит үнэ цэнийн тодорхойлолтонд “харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээ” гэж заасан. Харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээ нь зах зээлийн нөхцөл байдалд нийтлэг бус тийм ажил гүйлгээний үнэ тогтоох тухайлсан буюу тусгай харилцан холбоогүй талуудын хоорондох ажил гүйлгээ юм. Тухайн ажил гүйлгээг тус бүрдээ бие даасан байдлаар үйл ажиллагаа явуулдаг холбоогүй талуудын хооронд хийнэ гэж үздэг.

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗОРИУЛАЛТТАЙ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

54. Нэг байршил, нөхцөлд байгаа ба нэг ижил түрээсийн болон бусад гэрээний зүйл болох, ижил төсөөтэй хөрөнгийн идэвхитэй зах зээлийн одоогийн үнэ нь бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо болдог. Байгууллага нь тухайн үл хөдлөх хөрөнгийн шинж төрөл, байршил, чанар байдлын буюу тэрхүү үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой түрээсийн болон бусад гэрээний нөхцөл заалтуудын аливаа ялгаатай байдлыг тогтоохын тулд анхаарал хандуулна.
55. 54-р параграфт дурдсан шинж бүхий зүйлсийн хувьд идэвхитэй зах зээлийн одоогийн үнэ байхгүй бол байгууллага нь янз бүрийн эх үүсвэрээс авсан дараах мэдээллийг харгалзан үзнэ. Үүнд:
- (а) Өөр шинж төрөл, чанар байдал, байршил бүхий (эсвэл өөр түрээсийн болон бусад гэрээний зүйл болох) үл хөдлөх хөрөнгийн хувьд тэдгээр ялгаатай байдлыг тусгахын тулд залруулга хийсэн, идэвхитэй зах зээлийн одоогийн үнүүд;
  - (б) Арай идэвхи багатай зах зээлд тухайн ажил гүйлгээ хийгдсэн өдрөөс хойш, эдийн засгийн нөхцөл байдалд орсон аливаа өөрчлөлтийг тусгахын тулд хийсэн залруулгын хамтаар тэдгээр ижил төсөөтэй үл хөдлөх хөрөнгийн хамгийн сүүлийн үеийн үнүүд; ба
  - (в) Ирээдүйн мөнгөн гүйлгээний найдвартай тооцоололд үндэслэсэн ба одоо мөрдөж буй түрээсийн болон бусад гэрээний нөхцлүүдэд заагдсан, түүнчлэн (хэрэв боломжтой бол) нэг ижил байршил, чанар байдал бүхий ижил төсөөтэй үл хөдлөх хөрөнгүүдийн одоогийн зах зээлийн түрээс гэх мэт гаднын нотолгоогоор дэмжигдсэн, мөнгөн гүйлгээний дүн ба цаг хугацааны тодорхойгүй байдлын хувьд одоогийн зах зээлийн үнэлгээг тусгах тийм дискаунтын хувь хэмжээг ашиглан тооцсон, дискаунтчилсан мөнгөн гүйлгээний төсөвлөлт.
56. Зарим тохиолдолд өмнөх параграфт дурдсан, янз бүрийн эх үүсвэр нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийн талаар өөр өөр дүгнэлтүүдийг санал болгож болох юм. Ул үндэслэлтэй бодит үнэ цэнийн тооцооллын муж доторх бодит үнэ цэнийн хамгийн найдвартай тооцоололд хүрэхийн тулд байгууллага нь тэдгээр зөрүүтэй байдлын учир шалтгааныг харгалзан үзнэ.
57. Байгууллага нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг анх худалдан авах үед (эсвэл одоо байгаа үл хөдлөх хөрөнгийн ашиглалтыг өөрчилснөөр түүнийг анх удаа хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө болгох үед) бодит үнэ цэнийн ул үндэслэлтэй тооцооллын мужийн хувьсан өөрчлөлт маш их бөгөөд янз бүрийн үр дүнгүүдийн магадлалыг үнэлэхэд ихээхэн төвөгтэй байх хэвийн бус гажих тохиолдолд бодит үнэ цэнийн нэг тооцоолол ач холбогдолгүй байдаг. Энэ нь үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийг тасралтгүй сууриар найдвартай тодорхойлох боломжгүй гэдгийг илэрхийлж болох юм (62-р параграфыг үзнэ үү).
58. Бодит үнэ цэнэ нь УСНББОУС 21, *Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*, УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ*

*Цэнийн Бууралт*-д тодорхойлсончлон, ашиглалтын үнэ цэнээс ялгаатай байдаг. Бодит үнэ цэнэ нь зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа худалдан авагч ба борлуулагч талуудын мэдлэг болон тооцооллыг тусгадаг. Харин ашиглалтын үнэ цэнэ нь тухайн байгууллагын тооцоолол үүнд, ерөнхийдөө байгууллагуудад хамаарах биш, харин уг байгууллагад тусгайлан хамаарч болох хүчин зүйлсийн нөлөөг тусгадаг. Жишээлбэл; зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа худалдан авагч ба борлуулагч нар ерөнхийдөө олж авах боломжгүй байх тохиолдолд дараах аль нэг хүчин зүйлсийг бодит үнэ цэнэд тусгадаггүй:

- (a) Өөр өөр байршил дахь үл хөдлөх хөрөнгүүдийн багц үүсгэснээр бий болох нэмэлт үнэ цэнэ;
- (б) Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө ба бусад хөрөнгүүдийн хоорондох өргөжилтийн хэмнэлт;
- (в) Зөвхөн одоогийн өмчлөгчид тусгайлан хамаарах хууль ёсны эрх буюу хууль эрх зүйн хязгаарлалтууд; ба
- (г) Одоогийн өмчлөгчид тусгайлан хамаарах татварын өгөөж буюу татварын дарамт.

59. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дансны үнийг бодит үнэ цэнийн загварын дагуу тодорхойлохдоо, байгууллага нь тусдаа хөрөнгө буюу тусдаа өр төлбөр байдлаар хүлээн зөвшөөрсөн хөрөнгө, өр төлбөрийг давхар тооцохгүй. Тухайлбал;

- (a) Цахилгаан шат, агааржуулагч гэх мэт тоног төхөөрөмж нь ихэвчлэн барилгын салшгүй нэг хэсэг болдог бөгөөд тэдгээрийг тусад нь үндсэн хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхийн оронд, ерөнхийдөө тухайн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнэд тусган оруулдаг.
- (б) Хэрэв оффисыг бүрэн тохижуулсан байдлаар түрээслэдэг бол түрээсийн орлого нь бүрэн тохижуулсан оффисод хамаарах тул тухайн оффисын бодит үнэ цэнэд ерөнхийдөө тавилгын бодит үнэ цэнэ багтсан байна. Тавилга нь уг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнэд багтсан тохиолдолд байгууллага нь тавилгыг тусдаа хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхгүй.
- (в) Урьдчилж төлсөн эсвэл хуримтлуулсан үйл ажиллагааны түрээсийн орлогыг байгууллага нь тусдаа өр төлбөр эсвэл тусдаа хөрөнгө гэж хүлээн зөвшөөрдөг тул эдгээр нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнэд хамаарахгүй.
- (г) Түрээсийн дагуу эзэмшиж буй хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнэ нь хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг (үүнд өглөг үүсгэхээр хүлээгдэж буй түрээсийн хувьсах төлбөрүүд хамаарна) тусгадаг. Иймээс хэрэв үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ нь тухайн төлөхөөр хүлээгдэж буй бүх төлбөрүүдийг хассан цэвэр дүн байвал бодит үнэ цэнийн загварыг ашиглан тухайн хөрөнгө

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗОРИУЛАЛТТАЙ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дансны үнийг гаргахын тулд аливаа хүлээн зөвшөөрсөн түрээсийн өр төлбөрийг буцаан нэмнэ.

60. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнэ нь уг үл хөдлөх хөрөнгийг сайжруулах буюу нэмэгдүүлэх ирээдүйн капитал зарлага, түүнчлэн энэхүү ирээдүйн капитал зарлагаас бий болох ирээдүйн холбогдох үр өгөөжийг тусгадаггүй.
61. Зарим тохиолдолд байгууллага нь тухайн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөнд хамаарах түүний төлбөрүүдийн (хүлээн зөвшөөрсөн өр төлбөртэй холбоотой төлбөрүүдээс бусад) өнөөгийн үнэ цэнэ нь холбогдох мөнгөн орлогын өнөөгийн үнэ цэнээс хэтэрч давна гэж хүлээж байдаг. Байгууллага нь өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх эсэх, хэрэв зөвшөөрөх бол түүнийг хэрхэн хэмжих эсэхийг тодорхойлохын тулд УСНББОУС 37, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-ийг дагаж мөрдөнө.

*Бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй байдал*

62. Байгууллага нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийг тасралтгүй сууриар, найдвартай хэмжиж чадна гэсэн няцааж болох урьдчилсан нөхцөл байдаг. Гэвч хэвийн бус гажих тохиолдолд байгууллага нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг анх худалдан авах үед (эсвэл одоо байгаа үл хөдлөх хөрөнгийн ашиглалтыг өөрчилснөөр түүнийг анх удаа хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө болгох үед) уг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийг тасралтгүй сууриар, найдвартай хэмжих боломжгүй гэсэн илт тодорхой нотолгоо байдаг. Зах зээлийн зэрэгцүүлэгдэх ажил гүйлгээ цөөн бөгөөд бодит үнэ цэнийн өөр найдвартай өөр хувилбар (жишээлбэл; дискаунтчилсан мөнгөн гүйлгээний төсөвлөлтөнд үндэслэн) тооцоолол хийх боломжгүй зөвхөн тийм тохиолдолд ийм нөхцөл байдал үүсдэг. Байгууллага нь баригдаж буй, дуусаагүй хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй гэж тодорхойлсон боловч барилгын ажил дууссан үед уг үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжтой гэж хүлээж байгаа тохиолдолд түүний бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжтой болох эсвэл барилгын ажил дуусах (аль түрүүнд болох хугацаа) хүртэл тухайн баригдаж буй, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг өртгөөр нь хэмжинэ. Хэрэв байгууллага нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн (баригдаж буй хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөөс бусад) бодит үнэ цэнийг тасралтгүй сууриар найдвартай хэмжих боломжгүй гэж тодорхойлсон бол тухайн байгууллага нь УСНББОУС 17-д заасан өртгийн загварыг ашигласнаар уг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг хэмжинэ. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх



**хөрөнгийн үлдэх өртгийг тэг гэж үзнэ. Байгууллага нь тухайн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг данснаас хасах хүртэл УСНББОУС 17-г мөрдөнө.**

- 62А. Өмнө нь өртгөөр хэмжиж байсан, баригдаж буй хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийг байгууллага нь найдвартай хэмжих боломжтой болмогц уг үл хөдлөх хөрөнгийг түүний бодит үнэ цэнээр хэмжинэ. Тухайн үл хөдлөх хөрөнгийн барилгын ажил дуусмагц түүний бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадна гэсэн урьдчилсан нөхцөлтэй болдог. Хэрэв бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй бол 62-р параграфт заасанчлан, уг үл хөдлөх хөрөнгийг УСНББОУС 17-гийн дагуу өртгийн загвар ашигласнаар тайлагнана.
- 62Б. Баригдаж буй хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадна гэсэн урьдчилсан нөхцлийг зөвхөн анхны хүлээн зөвшөөрөлтийн үед няцааж болно. Баригдаж буй хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмжсэн байгууллага нь тухайн баригдаж дууссан, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй гэж дүгнэж болохгүй.
63. Байгууллага нь 62-р параграфт дурдсан шалтгаан үндэслэлийг харгалзан, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөө УСНББОУС 17-д заасан өртгийн загвар ашиглан хэмжих шаардлагатай болсон хэвийн бус гажих тохиолдолд тухайн байгууллага нь өөрийн бусад бүх хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг, үүн дотроо баригдаж буй хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг бодит үнэ цэнээр нь хэмжинэ. Энэ тохиолдолд байгууллага нь хөрөнгө оруулалтын зориулалттай нэг үл хөдлөх хөрөнгийн хувьд өртгийн загвар ашиглаж болох боловч бусад үл хөдлөх хөрөнгө нэг бүрийг бодит үнэ цэнийн загвар ашиглан тайлагнасан хэвээр байна.
64. Хэрэв байгууллага нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг өмнө нь бодит үнэ цэнээр хэмжсэн бол тухайн үл хөдлөх хөрөнгөтэй зэрэгцүүлэгдэх зах зээлийн ажил гүйлгээ цөөхөн болсон эсвэл зах зээлийн үнэ бэлэн боломжтой байхаа больсон ч гэсэн тэрхүү үл хөдлөх хөрөнгийг данснаас хасах хүртэл (уг үл хөдлөх хөрөнгө нь эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгө болох эсвэл байгууллага нь хэвийн үйл ажиллагааны явцад дараа нь борлуулахын тулд тухайн үл хөдлөх хөрөнгийг хөгжүүлж эхлэх хүртэл) бодит үнэ цэнээр хэмжсэн хэвээр байна.

#### **Өртгийн загвар**

65. Өртгийн загварыг сонгосон байгууллага нь анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, өөрийн хөрөнгө оруулалтын зориулалттай бүх үл хөдлөх хөрөнгийг УСНББОУС 17-гийн өртгийн загварт хамаарах шаардлагуудын дагуу, өөрөөр хэлбэл өртгөөс аливаа

**хуримтлагдсан элэгдэл ба аливаа хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр хэмжинэ.**

## **Шилжүүлэлт**

66. **Хөрөнгийн ашиглалтанд өөрчлөлт орсон бөгөөд дараах зүйлсээр нотлогдсон бол, зөвхөн тийм тохиолдолд үл хөдлөх хөрөнгийг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөнд эсвэл хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөөс үл хөдлөх хөрөнгөнд шилжүүлнэ:**
- (a) **Тухайн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгөнд шилжүүлэхэд хүргэх эзэн-ашиглалт эхлэх;**
  - (б) **Борлуулах үүднээс, тухайн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг бараа материалд шилжүүлэх зорилгоор хөгжүүлэлт хийж эхлэх;**
  - (в) **Эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгөөс хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөнд шилжүүлэхэд хүргэх эзэн-ашиглалт дуусах; эсвэл**
  - (г) **Бараа материалаас хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөнд шилжүүлэхэд хүргэх, нөгөө талд (арилжааны сууриар) түрээслэх үйл ажиллагааны түрээс эхлэх; ба**
  - (д) [Хассан]
67. Засгийн газрын үл хөдлөх хөрөнгийн ашиглалт нь цаг хугацааны явцад өөрчлөгдөж болно. Жишээлбэл; засгийн газар нь одоо хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө байдлаар ашиглаж буй барилгаа өөрөө ашиглах, эсвэл тэнгисийн цэргийн хуаран буюу захиргааны оффисын зорилгоор одоо ашиглаж буй барилгыг зочид буудал болгон өөрчлөх ба тэрхүү барилгыг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид шилжүүлэхээр шийдвэрлэж болох юм. Өөрөө ашиглахаар болох тохиолдолд ийм ашиглалт эхлэх хүртэл тухайн барилгыг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэж тайлагнана. Харин зочид буудал болгон ашиглах сүүлийн тохиолдолд, түүний ашиглалтыг зогсоох хүртэл уг барилгыг үндсэн хөрөнгө гэж тайлагнах бөгөөд дараа нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэж дахин ангилна.
68. Борлуулах зорилго бүхий хөгжүүлэлтээр нотлогдох, ийм ашиглалтын өөрчлөлт гарсан бол, зөвхөн тийм тохиолдолд байгууллага нь уг үл хөдлөх хөрөнгийг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөөс бараа материал болгон шилжүүлэхийг 66(б) параграфтаар шаардсан байдаг. Байгууллага нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг хөгжүүлэлт хийхгүйгээр данснаас хасахаар шийдвэрлэсэн тохиолдолд уг үл хөдлөх хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх (санхүүгийн байдлын тайлангаас хасах) хүртэл хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэж бүртгэсэн хэвээр байх бөгөөд бараа материал гэж

үзэхгүй. Үүнтэй адилаар, хэрэв байгууллага нь одоо байгаа хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг ирээдүйд хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө байдлаар ашигласан хэвээр байхын тулд дахин хөгжүүлж эхэлсэн бол уг үл хөдлөх хөрөнгө нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө хэвээр үлдэх бөгөөд тухайн дахин хөгжүүлэлтийн явцад эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгө гэж дахин ангилахгүй.

69. Засгийн газрын үл хөдлөх хөрөнгийн хэлтэс нь түүний шаардлагууд хангагдаж буй эсэхийг тодорхойлохын тулд өөрийн барилгуудыг үечлэн нягталж шалгадаг бөгөөд энэхүү үйл явцын нэг хэсэг болгон зарим барилгыг борлуулах зорилготой гэж тодорхойлж, ингэж эзэмшиж болно. Энэ тохиолдолд тухайн барилгыг бараа материал гэж үзэж болох юм. Гэвч засгийн газар нь түрээсийн орлого олох болон капиталын үнийг өсгөх зорилгоор уг барилгыг эзэмшихээр шийдвэрлэсэн бол аливаа дараагийн тайлант үед үйл ажиллагааны түрээс эхэлсэн өдрөөр түүнийг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэж дахин ангилна.
70. Байгууллага нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хувьд бодит үнэ цэнийн загварыг ашиглах үед үүсдэг хүлээн зөвшөөрөлтийн болон хэмжилтийн асуудлуудын хувьд 71-76-р параграфыг мөрдөнө. Байгууллага нь өртгийн загварыг ашигладаг тохиолдолд хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө ба эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгө, бараа материалын хооронд хийгдэх шилжүүлэлт нь тухайн шилжүүлсэн үл хөдлөх хөрөнгийн дансны үнийг өөрчлөхгүй, мөн хэмжилт буюу тодруулгын зорилгоор уг үл хөдлөх хөрөнгийн өртгийг өөрчлөхгүй.
71. **Бодит үнэ цэнээр бүртгэсэн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгөнд эсвэл бараа материалд ангилах шилжүүлэлтийн хувьд УСНББОУС 17 буюу УСНББОУС 12-ын дагуу дараагийн тайлант үед бүртгэх тухайн үл хөдлөх хөрөнгийн өртөг нь хөрөнгийн ашиглалтын өөрчлөлт хийсэн өдрөөрх түүний бодит үнэ цэнэ байна.**
72. **Хэрэв эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгө нь бодит үнэ цэнээр бүртгэсэн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө болвол байгууллага нь тухайн хөрөнгийн ашиглалтыг өөрчлөх өдөр хүртэл УСНББОУС 17-г мөрдөнө. УСНББОУС 17-гийн дагуу тодорхойлсон үл хөдлөх хөрөнгийн дансны үнэ ба түүний бодит үнэ цэнийн хоорондох аливаа зөрүүг байгууллага нь УСНББОУС 17-гийн дагуу дахин үнэлгээг бүртгэдэгтэй ижил арга замаар тухайн өдөр тайлагнана.**
73. Эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгө нь бодит үнэ цэнээр бүртгэдэг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө болох өдөр хүртэл байгууллага нь тухайн үл хөдлөх хөрөнгийг элэгдүүлэх бөгөөд үүссэн аливаа үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрнө. УСНББОУС 17-гийн дагуу тодорхойлсон үл хөдлөх хөрөнгийн дансны үнэ ба түүний

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗОРИУЛАЛТТАЙ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

бодит үнэ цэнийн хоорондох аливаа зөрүүг байгууллага нь УСНББОУС 17-гийн дагуу дахин үнэлгээг бүртгэдэгтэй ижил арга замаар тухайн өдөр тайлагнана. Өөрөөр хэлбэл:

- (a) Үл хөдлөх хөрөнгийн дансны үнийн аливаа үр дүнгийн бууралтыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Гэхдээ тухайн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлд тусгасан дүнгийн хэмжээгээр уг бууралтыг тэрхүү дахин үнэлгээний нэмэгдлээс хасна.
- (б) Дансны үнийн аливаа үр дүнгийн өсөлтийг дараах байдлаар бүртгэнэ:
  - (i) Уг өсөлт нь тухайн үл хөдлөх хөрөнгийн өмнөх үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах хэмжээгээр тэрхүү өсөлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Ингэж ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх дүн нь хэрэв ямар нэг үнэ цэнийн бууралтын гарз хүлээн зөвшөөрөөгүй байсан бол тодорхойлогдох байсан дансны үнэ (элэгдлийг хассан цэвэр дүн) хүртэл уг дансны үнийг нэмэгдүүлэхэд шаардлагатай дүнгээс хэтрэхгүй.
  - (ii) Дансны үнийн өсөлтийн аливаа үлдсэн хэсгийг цэвэр хөрөнгө/өмч дэх дахин үнэлгээний нэмэгдэлд шууд кредитлэнэ. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг дараа данснаас хасах үед цэвэр хөрөнгө/өмчид тусгагдсан уг дахин үнэлгээний нэмэгдлийг хуримтлагдсан ашиг, алдагдалд шилжүүлж болно. Дахин үнэлгээний нэмэгдлээс хуримтлагдсан ашигт шилжүүлэлт хийхдээ ашиг, алдагдлаар дамжуулахгүй.

74. **Бодит үнэ цэнээр бүртгэх хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөнд бараа материалаас хийгдэх шилжүүлэлтийн хувьд уг өдрөөрх тухайн үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнэ ба түүний өмнөх дансны үнийн хоорондох аливаа зөрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.**

75. Бодит үнэ цэнээр бүртгэх хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөнд бараа материалаас хийгдэх шилжүүлэлтийн бүртгэлийн арга хандлага нь бараа материалын борлуулалтыг бүртгэх арга хандлагатай нийцсэн байна.

76. **Бодит үнэ цэнээр бүртгэх, өөрөө барьж байгуулсан хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн барилгын ажил эсвэл хөгжүүлэлт дууссан үед байгууллага нь уг өдрөөрх тухайн үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнэ ба түүний өмнөх дансны үнийн хоорондох аливаа зөрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.**

### **Данснаас хасалт**

77. **Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг данснаас хассан эсвэл тухайн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг ашиглалтаас бүрэн гаргасан ба түүний данснаас хасалтаас**

**ирээдүйд эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи хүртэхээргүй болсон тохиолдолд уг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө (санхүүгийн байдлын тайлангаас хасна).**

78. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг борлуулснаар эсвэл санхүүгийн түрээсээр өгснөөр данснаас хасаж болно. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн данснаас хасалтын өдрийг тодорхойлохдоо, байгууллага нь бараа борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрөх талаархи УСНББОУС 9-ийн шалгуурыг мөрдөх бөгөөд УСНББОУС 9-ийн Хэрэгжүүлэх Заавар Удирдамжид тусгагдсан холбогдох заавар удирдамжийг харгалзан үзнэ. Санхүүгийн түрээсээр өгснөөр хийгдэх данснаас хасалт, борлуулах ба буцаан түрээслэх ажил гүйлгээний хувьд УСНББОУС 13-ыг мөрдөнө.
79. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн зарим хэсгийн сольж орлуулах өртгийг байгууллага нь 20-р параграфт заасан хүлээн зөвшөөрөлтийн зарчмын дагуу тухайн хөрөнгийн дансны үнэд хүлээн зөвшөөрсөн бол уг сольж орлуулагдсан хэсгийн дансны үнийг үл хүлээн зөвшөөрнө. Өртгийн загвар ашиглан тайлагнадаг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хувьд, сольж орлуулагдсан хэсэг нь тусдаа элэгдүүлдэг хэсэг биш байж болох юм. Тухайн сольж орлуулагдсан хэсгийн дансны үнийг тодорхойлох практик боломжгүй бол байгууллага нь уг сольж орлуулагдсан хэсгийг худалдан авах эсвэл барьж байгуулах тэрхүү хугацаан дахь түүний өртгийн илэрхийлэл гэдэг утгаар уг сольж орлож буй хэсгийн өртгийг ашиглаж болно. Бодит үнэ цэнийн загварыг ашигладаг тохиолдолд уг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнэ нь тэрхүү үнэ цэнээ алдсан, сольж орлуулагдаж буй хэсгийг нэгэнт тусгасан байж болох юм. Үүнээс бусад тохиолдолд тэрхүү сольж орлуулагдаж буй хэсгээр бодит үнэ цэнийг хэдээр бууруулахыг тодорхойлоход төвөгтэй байж болно. Сольж орлуулагдсан хэсэгтэй холбоотойгоор бодит үнэ цэнийг бууруулах практик боломжгүй тохиолдолд түүний хувьд бодит үнэ цэнийг бууруулах өөр нэг хувилбар нь сольж орлож (нэмэгдэж) буй хэсгийн өртгийг тухайн хөрөнгийн дансны үнэ дээр нэмж тусгах ба үүний дараа тэрхүү сольж орлуулагдсан хэсгийг хассан, нэмэгдэлт бүхий хэсэгт хамаарах дүн байдлаар бодит үнэ цэнийг дахин үнэлж, тогтооно.
80. **Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн ашиглалтаас хасалт буюу данснаас хасалтаас үүссэн олз, гарзыг тухайн хөрөнгийн данснаас хасалтын цэвэр орлого ба түүний дансны үнийн хоорондох зөрүүгээр тодорхойлох бөгөөд уг ашиглалтаас хасалт буюу данснаас хасалтыг хийсэн тайлант үеийн ашиг, алдагдал (борлуулах ба буцаан түрээслэх ажил гүйлгээний хувьд УСНББОУС 13-д өөрөөр шаардсанаас бусад тохиолдолд)-д хүлээн зөвшөөрнө.**
81. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн данснаас хасалтаар хүлээн авах төлбөрийг эхлээд бодит үнэ цэнээр хүлээн

зөвшөөрнө. Ялангуяа хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн төлбөрийг хойшлуулсан бол уг хүлээн авах төлбөрийг эхлээд түүний мөнгөн үнэтэй адилтгах дүнгээр хүлээн зөвшөөрнө. Төлбөрийн нэрлэсэн дүн ба мөнгөн үнэтэй адилтгах дүнгийн хоорондох зөрүүг УСНББОУС 9-ийн дагуу үр ашигтай хүүний арга ашигласнаар хүүний орлого гэж хүлээн зөвшөөрнө.

82. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг данснаас хассаны дараа үлдсэн аливаа өр төлбөрийн хувьд байгууллага нь УСНББОУС 19 буюу бусад холбогдох Стандартын аль тохиромжтойг мөрдөнө.
83. **Үнэ цэнэ буурсан, алдагдсан, бусдад өгсөн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хувьд гуравдагч талаас авах нөхөн төлбөрийг хүлээн авахаар болсон үед нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.**
84. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийн бууралт буюу гарз, гуравдагч талаас авах нөхөн төлбөрийн холбогдох нэхэмжлэл буюу төлбөр, орлуулагдсан хөрөнгийн дараагийн аливаа худалдан авалт буюу барьж байгуулалт нь тусдаа эдийн засгийн үйл явдлууд бөгөөд тэдгээрийг тус тусад нь дараах байдлаар тайлагнана:
- (а) Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг УСНББОУС 21 эсвэл УСНББОУС 26-гийн аль тохиромжтой стандартын дагуу хүлээн зөвшөөрнө;
  - (б) Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн ашиглалтаас хасалт буюу данснаас хасалтыг энэхүү Стандартын 77-82-р параграфын дагуу хүлээн зөвшөөрнө;
  - (в) Үнэ цэнэ буурсан, алдагдсан, бусдад өгсөн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хувьд гуравдагч талаас авах нөхөн төлбөрийг хүлээн авахаар болсон үед нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө; ба
  - (г) Орлуулалт байдлаар нөхөн сэргээсэн, худалдан авсан буюу барьж байгуулсан хөрөнгийн өртгийг энэ Стандартын 26-38-р параграфын дагуу тодорхойлно.

## Тодруулга

### Бодит үнэ цэнийн загвар ба өртгийн загвар

85. УСНББОУС 13-д заасан тодруулгаас гадна доор дурдсан тодруулгыг хийнэ. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн эзэн нь үл хөдлөх хөрөнгийнхөө түрээсийн хувьд түрээслүүлэгчийн зүгээс хийх тодруулгаа УСНББОУС 13-ын дагуу бэлтгэнэ. Санхүүгийн түрээсийн эсвэл үйл ажиллагааны түрээсийн дагуу хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг эзэмшдэг байгууллага нь өөрийн байгуулсан санхүүгийн түрээсийн хувьд түрээслэгчийн зүгээс хийгдэх тодруулгыг, харин тухайн

хөрөнгийг өөрөө түрээслүүлсэн бол аливаа үйл ажиллагааны түрээсийнхээ хувьд түрээслүүлэгчийн зүгээс хийгдэх тодруулгыг бэлтгэнэ.

86. **Аж ахуйн нэгж нь дараах зүйлсийг тодруулна:**

- (a) Бодит үнэ цэнийн загвар эсвэл өртгийн загварын алийг хэрэглэж байгаа эсэх;
- (б) Хэрэв бодит үнэ цэнийн загварыг хэрэглэж байгаа бол үйл ажиллагааны түрээсийн дагуу эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийн хувь оролцоогоо ямар нөхцөлд хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэж ангилж тайлагнах эсэх;
- (в) Ангилал хийхэд төвөгтэй байгаа тохиолдолд (18-р параграфыг үзнэ үү), хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгөөс болон хэвийн үйл ажиллагааны явцад борлуулах зорилгоор эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгөөс ялгахын тулд тухайн байгууллагын ашигладаг шалгуур;
- (г) Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо хэрэглэсэн арга ба чухал таамаглалууд, үүн дотроо уг бодит үнэ цэнийн тодорхойлолт нь зах зээлийн нотолгоогоор дэмжигдсэн эсвэл тухайн үл хөдлөх хөрөнгийн шинж төрөл болон зэрэгцүүлэгдэх зах зээлийн мэдээний хомс байдлаас шалтгаалан (байгууллагын тодруулвал зохих) бусад хүчин зүйлсэд голчлон тулгуурладаг эсэх талаархи мэдэгдэл;
- (д) Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнэ (санхүүгийн тайланд хэмжиж, тодруулсан) нь мэргэжлийн хүлээн зөвшөөрөгдсөн зохих ур чадвартай бөгөөд тухайн үнэлж буй хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн байршил, төрөл зүйлийн талаар сүүлийн үеийн туршлагатай хараат бус үнэлгээчний хийсэн үнэлгээнд үндэслэсэн хэмжээ. Хэрэв ийм үнэлгээ хийгдээгүй бол энэ тухай тодруулга хийнэ.
- (e) Доорх зүйлсийн хувьд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн дүн:
  - (i) Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөөс олох түрээсийн орлого;
  - (ii) Тухайн тайлант үеийн туршид түрээсийн орлого бий болгосон хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой үйл ажиллагааны шууд зардал (үүн дотроо засвар, үйлчилгээний зардал); ба
  - (iii) Тухайн тайлант үеийн туршид түрээсийн орлого бий болгоогүй хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой үйл ажиллагааны шууд зардал (үүн дотроо засвар, үйлчилгээний зардал).

- (ж) Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн борлуулалт эсвэл орлогын шилжүүлэлт, данснаас хасалтын мөнгөн орлогын шилжүүлэлтэнд тавигдах хязгаарлалт байгаа эсэх болон хязгаарлалтын дүн хэмжээ; ба
- (и) Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг худалдан авах, барьж байгуулах, хөгжүүлэх эсвэл засвар, үйлчилгээ, сайжруулалт хийх талаархи гэрээний үүрэг.

*Бодит үнэ цэнийн загвар*

87. 42-64-р параграфт заасан бодит үнэ цэнийн загварыг ашигладаг байгууллага нь 86-р параграфтаар шаардсан тодруулгаас гадна хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн тухайн тайлант үеийн эхэн ба эцэс дэх дансны үнэ хоорондох тохируулгын тайланг бэлтгэж толилуулах бөгөөд үүнд дараах зүйлсийг харуулна:
- (а) Нэмэгдэлт, үүнд: худалдан авалтын үр дүнд нэмэгдсэн хөрөнгө ба тухайн хөрөнгийн дансны үнэд хүлээн зөвшөөрсөн дараагийн тайлант үеийн зарлагын үр дүнд нэмэгдсэн хөрөнгийг тусдаа тодруулах;
  - (б) Улсын секторын нэгдлээр олж эзэмшсэн нэмэгдэлт;
  - (в) Данснаас хасалт;
  - (г) Бодит үнэ цэнийн тохируулгаас үүссэн цэвэр олз буюу гарз;
  - (д) Санхүүгийн тайланг толилуулгын өөр валютанд хөрвүүлснээс, түүнчлэн гадаад үйл ажиллагааг тухайн тайлагнагч байгууллагын толилуулгын валютанд хөрвүүлснээс үүссэн ханшийн цэвэр зөрүү;
  - (е) Бараа материал ба эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгийн хоорондох ангиллын шилжүүлэлт; ба
  - (ж) Бусад өөрчлөлтүүд.
88. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хувьд хийсэн үнэлгээг санхүүгийн тайлангийн зорилгоор мэдэгдэхүйц дүнгээр залруулдаг, тухайлбал; 59-р параграфт заасны дагуу тусдаа хөрөнгө, өр төлбөр гэж хүлээн зөвшөөрдөг хөрөнгө буюу өр төлбөрийг давхардуулан тооцохоос зайлсхийхийн тулд залруулдаг тохиолдолд тухайн байгууллага нь уг хийсэн үнэлгээ ба санхүүгийн тайланд тусгасан, залруулсан үнэлгээний хоорондох тохируулгыг толилуулна. Буцаан нэмсэн, аливаа хүлээн зөвшөөрсөн түрээсийн өр төлбөрүүдийн нийт дүн ба аливаа бусад мэдэгдэхүйц дүн бүхий залруулгыг уг тохируулгын тайланд тусдаа харуулна.
89. 62-р параграфт дурдсан хэвийн бус гажих тохиолдолд, байгууллага нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөө УСНББОУС 17-д заасан өртгийн загварыг ашиглан хэмжсэн бол 87-р параграфтаар шаардсан тохируулгын тайланд тухайн хөрөнгө



оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөнд хамаарах дүнгүүдийг бусад хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөнд хамаарах дүнгүүдээс тусад нь тодруулж, харуулна. Түүнчлэн, байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:

- (a) Тухайн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн тайлбар тодорхойлолт;
- (б) Бодит үнэ цэнийг яагаад найдвартай хэмжиж чадахгүй байгаа талаархи тайлбар;
- (в) Хэрэв боломжтой бол бодит үнэ цэнэ нь хамаарах ихээхэн магадлалтай тооцооллын муж; ба
- (г) Бодит үнэ цэнээр нь бүртгээгүй хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн данснаас хасалтын хувьд:
  - (i) Бодит үнэ цэнээр нь бүртгээгүй хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг уг байгууллага данснаас хассан тухай;
  - (ii) Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг борлуулах үе дэх түүний дансны үнэ; ба
  - (iii) Хүлээн зөвшөөрсөн олз буюу гарзын дүн.

*Өртгийн загвар*

90. 65-р параграфт дурдсан өртгийн загварыг ашигладаг байгууллага нь 86-р параграфтаар шаардсан тодруулгаас гадна дараах зүйлсийг тодруулна:

- (a) Ашигласан элэгдэл тооцох арга;
- (б) Ашиглалтын хугацаа буюу ашигласан элэгдлийн хувь хэмжээ;
- (в) Тайлант үеийн эхэн ба эцэс дэх нийт дансны үнэ ба хуримтлагдсан элэгдэл (хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзтай нэгтгэн нийлүүлсэн);
- (г) Доорх зүйлсийг харуулсан, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн тайлант үеийн эхэн ба эцэс дэх дансны үнийн тохируулга:
  - (i) Нэмэгдэлт, үүнд: худалдан авалтын үр дүнд нэмэгдсэн хөрнгө ба хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн дараагийн тайлант үеийн зарлагын үр дүнд нэмэгдсэн хөрөнгийг тусдаа тодруулах;
  - (ii) Улсын секторын нэгдлээр олж эзэмшсэн, нэмэгдсэн хөрөнгө;
  - (iii) Данснаас хасалт;
  - (iv) Элэгдэл;

- (v) **УСНББОУС 21 эсвэл УСНББОУС 26-гийн аль тохиромжтой стандартын дагуу тухайн тайлант үеийн туршид хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзын дүн ба буцаасан үнэ цэнийн бууралтын гарзын дүн;**
  - (vi) **Санхүүгийн тайланг толилуулгын өөр валютанд хөрвүүлснээс, түүнчлэн гадаад үйл ажиллагааг тухайн тайлагнагч байгууллагын толилуулгын валютанд хөрвүүлснээс үүссэн ханшийн цэвэр зөрүү;**
  - (vii) **Бараа материал ба эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгийн хоорондох ангиллын шилжүүлэлт; ба**
  - (viii) **Бусад өөрчлөлтүүд.**
- (д) **Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнэ. 62-р параграфт дурдсан хэвийн бус гажих тохиолдолд, байгууллага нь тухайн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадахгүй бол дараах зүйлсийг тодруулна:**
- (i) **Тухайн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн тайлбар тодорхойлолт;**
  - (ii) **Бодит үнэ цэнийг яагаад найдвартай хэмжиж чадахгүй байгаа талаархи тайлбар; ба**
  - (iii) **Хэрэв боломжтой бол бодит үнэ цэнэ нь хамаарах ихээхэн магадлалтай тооцооллын муж.**

### **Шилжилтийн нөхцөл**

91. [Хассан]

92. [Хассан]

93. [Хассан]

### **Бодит үнэ цэнийн загвар**

94. [Хассан]

95. [Хассан]

96. [Хассан]

97. (a) УСНББОУС 16-г (2001 он) өмнө нь мөрдөж байсан, ба (б) үйл ажиллагааны түрээсийн дагуу эзэмшиж буй, зохих шалгуур хангасан зарим буюу бүх үл хөдлөх хөрөнгийн хувь оролцоогоо анх удаа хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэж ангилж, тайлагнах сонголт хийсэн байгууллага нь тэрхүү сонголтыг анх хийсэн тайлант үеийн хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдлийн залруулга байдлаар уг сонголтын үр нөлөөг хүлээн зөвшөөрнө. Түүнчлэн, хэрэв байгууллага нь

өмнөх тайлант үеүд дэх тэдгээр үл хөдлөх хөрөнгийн хувь оролцооны бодит үнэ цэнийг өмнө нь олон нийтэд (санхүүгийн тайландаа эсвэл өөр бусад байдлаар) толилуулж байсан бол 94(а) параграфыг мөрдөнө. Хэрэв байгууллага нь 94(а) параграфт дурдсан, тэдгээр үл хөдлөх хөрөнгийн хувь оролцоотой холбоотой мэдээллийг өмнө нь олон нийтэд толилуулж байгаагүй бол 94(б) параграфыг мөрдөнө.

### Өртгийн загвар

98. [Хассан]

99. [Хассан]

100. **УСНББОУС 16-г (2001 он) өмнө нь мөрдөж байсан байгууллагуудын хувьд, хөрөнгийг солилцох ажил гүйлгээгээр олж эзэмшсэн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн анхны хэмжилтийн талаархи 36-38-р параграфын шаардлагуудыг зөвхөн ирээдүйн ажил гүйлгээний хувьд гүйцээх горимоор мөрдөнө.**

### Хүчин төгөлдөр болох хугацаа

101. **Байгууллага нь энэхүү Стандартыг 2008 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2008 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.**

101A. **2010 оны 01 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Сайжруулалтууд*-аар 12, 13, 40, 57, 59, 62, 63, 66-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулж, 29-р параграфыг хассан ба 62A, 62B параграфыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2011 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд гүйцээх горимоор мөрдөнө. Хэрэв баригдаж буй хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийг энэхүү хугацаанаас өмнөх дурын нэг өдрүүдээр тодорхойлсон бол байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг тухайн баригдаж буй хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөнд 2011 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнөх тэдгээр өдрүүдээс эхлэн мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2011 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдвөл энэ тухай тодруулга хийх бөгөөд УСНББОУС 17-гийн 8 ба 107A параграфуудын нэмэлт өөрчлөлтүүдийг мөн тэрхүү өмнөх тайлант үед мөрдөнө.**

101B. **2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-ийн үр дүнд 91, 92, 93, 94, 95, 96, 98, 99, 102-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан.**

Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед УСНББОУС 33-ыг мөрдсөн бол эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.

- 101В. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд*-аар 40-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 101Г. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 3, 4-р параграфуудыг хасаж, 9-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 101Д. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийн үр дүнд 18А параграфыг шинээр нэмж, 87 ба 90-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд мөн тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.
102. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

## **УСНББОУС 16 (2001)-гаас татгалзах**

103. Энэ Стандарт нь 2001 онд гаргасан УСНББОУС 16, *Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө*-ийг орлоно.

## Дүгнэлтийн Үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 16-г дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### **НББОУС3-ийн Ерөнхий Сайжруулалтын Төсөл 2003-ын үр дүнд УСНББОУС 16-г хянан засварласан.**

#### *Оршил*

- ДҮ1. УСНББОУС3-ийн СТОУС-тай нийцүүлэх хөтөлбөр нь УСНББОУС3-ийн ажлын хөтөлбөрийн чухал элемент юм. УСНББОУС3-ийн бодлого нь улсын секторын байгууллагуудад тохиромжтой тохиолдолд НББОУС3-өөс гаргасан СТОУС-тай аккруэл суурьт УСНББОУС-ыг нийцүүлэх явдал юм.
- ДҮ2. Улсын секторын хувьд гажих тусгай учир шалтгаан байхаас бусад тохиолдолд СТОУС-тай нийцүүлсэн, аккруэл суурьт УСНББОУС нь СТОУС-ын шаардлага, бүтэц, текстийг тэр хэвээр хадгална. СТОУС-ын шаардлага буюу нэр томъёо нь улсын секторт тохиромжгүй эсвэл улсын секторын хувьд зарим тодорхой шаардлагуудыг үлгэрчлэн харуулахын тулд нэмэлт тайлбар буюу жишээ оруулах шаардлагатай тохиолдолд адилтгах СТОУС-аас гаждаг. УСНББОУС-ууд ба тэдгээртэй адилтгах СТОУС-уудын хоорондох ялгаатай талуудыг УСНББОУС нэг бүрд тусган оруулсан *СТОУС-тай Харьцуулалт*-д тодорхойлсон.
- ДҮ3. 2002 оны 5 дугаар сард өөрийн Ерөнхий Сайжруулалтын Төслийн нэг хэсэг болгон НББОУС3 нь 13-н Нягтлан Бодох Бүртгэлийн Стандарт (НББОУС)<sup>2</sup>-д оруулахаар санал болгосон нэмэлт өөрчлөлтийн саналын төслийг гаргасан. НББОУС3-ийн Ерөнхий Сайжруулалтын Төслийн зорилго нь “Стандартуудын хүрээн дэх сонголтод олон хувилбарууд, илүүдэл зүйлс, зөрчилтэй заалтуудыг арилгах буюу бууруулах, нийцүүлэлтийн зарим асуудлуудыг шийдэх ба бусад сайжруулалтыг хийх”-д оршино. НББОУС-ын эцсийн хувилбарыг 2003 оны 12 дугаар сард гаргасан.
- ДҮ4. 2001 оны 12 дугаар сард гаргасан УСНББОУС 16 нь НББОУС 40 (2000 он)-д үндэслэсэн. НББОУС 40-ийг 2003 оны 12 дугаар сард дахин гаргасан. УСНББОУС3-ийн өмнөх байгууллага болох Улсын Секторын Хороо (УСХ)<sup>3</sup> нь 2003 оны 12 дугаар сард гаргасан, сайжруулсан НББОУС-тай тохиромжтой хэмжээгээр УСНББОУС-ыг нийцүүлэхийн тулд УСНББОУС-ыг сайжруулах төслийг 2003 оны эцсээр хэрэгжүүлж эхэлсэн.

<sup>2</sup> НББОУС3-ийн өмнөх байгууллага болох НББОУСХ-ноос НББОУС-ыг гаргасан. НББОУС3-өөс гаргасан стандартуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) гэж нэрлэдэг. СТОУС-ыг НББОУС3 нь СТОУС, НББОУС, Стандартын Тайлбаруудаас бүрдэнэ гэж тодорхойлсон. Зарим тохиолдолд НББОУС3 нь НББОУС-ыг сольж орлуулахгүй, харин нэмэлт өөрчлөлт оруулдаг бөгөөд ингэснээр хуучин НББОУС-ын дугаарлалт хэвээр үлддэг.

<sup>3</sup> ДНБХ-ны Зөвлөл нь УСХ-г стандарт тогтоох бие даасан зөвлөл болгохын тулд түүний бүрэн эрхийг 2004 оны 11 дүгээр сард өөрчилснөөр УСХ нь УСНББОУС3 болсон.

- ДҮ5. УСНББОУСЗ нь уг сайжруулсан НББОУС 40-ийг нягталж шалгаад ингэж хянан засварлах болсон НББОУСЗ-ийн учир шалтгаан болон хийсэн нэмэлт өөрчлөлттэй ерөнхийдөө санал нэгдсэн. (НББОУСЗ-ийн Дүгнэлтийн Үндэслэлийг энд дахин нийтлээгүй болно. НББОУСЗ-ийн *Цогц Захиалгын Үйлчилгээ*-гээр захиалагч нар нь [www.iasb.org](http://www.iasb.org) хаягаар орж, НББОУСЗ-ийн вэб сайтаас Дүгнэлтийн Үндэслэлийг үзэж болно). УСНББОУС нь адилтгах НББОУС-аас гажих тохиолдолд улсын секторын хувьд гажих тусгай учир шалтгааныг Дүгнэлтийн Үндэслэлд тайлбарладаг.
- ДҮ6. 2003 оны 12 дугаар сараас хойш гаргасан СТОУС-уудын үр дүнд НББОУС 40-д цаашид нэмэлт өөрчлөлт оруулсан. 2003 оны 12 дугаар сараас хойш гаргасан СТОУС-уудын үр дүн болох нэмэлт өөрчлөлтүүдийг УСНББОУС 16-д тусган оруулаагүй байна. Яагаад гэвэл, УСНББОУСЗ нь тэдгээр СТОУС-уудын шаардлагуудыг нягтлан шалгаж, улсын секторын байгууллагуудад мөрдөгдөх боломжит байдлын талаар өөрийн үзэл бодлыг хараахан илэрхийлээгүй байгаа юм.

**2008 онд гаргасан, НББОУСЗ-ийн СТОУС-ын Сайжруулалтууд-ын үр дүнд УСНББОУС 16-д хийсэн хянан засварлалт**

- ДҮ7. УСНББОУСЗ нь 2008 оны 5 дугаар сард НББОУСЗ-өөс гаргасан *СТОУС-ын Сайжруулалтууд*-д тусгасан, НББОУС 40-ийн хянан засварлалтыг нягталж шалгаад уг Стандартыг хянан засварлах болсон НББОУСЗ-ийн учир шалтгаантай ерөнхийдөө санал нийлсэн. УСНББОУСЗ нь уг нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдөхгүй байх улсын секторын тусгай учир шалтгаан байхгүй гэж дүгнэсэн.


**2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУСЗ-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 16-д хийсэн хянан засварлалт**

- ДҮ8. УСНББОУСЗ нь 2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт нэмэлт өөрчлөлт оруулсан:
- (а) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
  - (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
  - (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р* параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

## Үлгэрчилсэн шийдвэрийн мод

Энэхүү шийдвэрийн мод нь УСНББОУС 16-г дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.



## НББОУС 40-ТЭЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 16-г НББОУС 40, *Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө* (2003)-өөс үндсэндээ бэлтгэсэн бөгөөд 2008 оны 5 дугаар сард гаргасан, *СТОУС-ын Сайжруулалтууд*-ын нэг хэсэг байдлаар НББОУС 40-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг үүнд тусгасан болно. Энэ Стандартыг гаргах үед УСНББОУСЗ нь улсын секторын байгууллагуудад *СТОУС 4, Даатгалын Гэрээ* болон *СТОУС 5, Борлуулах Зорилгоор Эзэмшиж Буй Эргэлтийн Бус Хөрөнгө ба Зогсоосон Үйл Ажиллагаа*-ны мөрдөгдөх боломжтой байдлыг харгалзан үзээгүй байсан; иймээс эдгээр *СТОУС*-уудыг гаргасны үр дүнд НББОУС 40-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг УСНББОУС 16-д тусгаагүй болно. УСНББОУС 16 ба НББОУС 40-ийн хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- УСНББОУС 16 нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг эхлээд өртгөөр хэмжихийг шаарддаг бөгөөд тухайн хөрөнгийг үнэгүй буюу нэрлэсэн өртгөөр олж эзэмшсэн тохиолдолд түүний өртөг нь тэрхүү олж эзэмшсэн өдрөөрх бодит үнэ цэнэ байна гэж тусгайлан заасан. Харин НББОУС 40 нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг эхлээд өртгөөр хэмжихийг шаарддаг.
- Нийгмийн үйлчилгээ үзүүлэхийн тулд эзэмшиж байгаа бөгөөд мөн мөнгөн орлогын гүйлгээ бий болгодог үл хөдлөх хөрөнгийн хувьд УСНББОУС 16-г мөрдөхгүй гэдгийг тодорхой болгохын тулд нэмэлт тайлбар оруулсан. Ийм үл хөдлөх хөрөнгийг УСНББОУС 17, *Үндсэн Хөрөнгө*-ийн дагуу тайлагнана.
- УСНББОУС 16 нь анх удаа мөрдөлт, түүнчлэн УСНББОУС 16-гийн өмнөх хувилбарт орсон өөрчлөлтийн аль алинд хамаарах шилжилтийн нөхцлүүдийг агуулсан байдаг. Харин НББОУС 40 нь *СТОУС*-уудыг аль хэдийн мөрдөж буй аж ахуйн нэгжүүдэд хамаарах шилжилтийн нөхцлүүдийг зөвхөн агуулсан байдаг. *СТОУС*-уудын анх удаа мөрдөлтийг *СТОУС 1*-д авч үзсэн. Байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийг анх удаа мөрдөх ба өмнө нь хүлээн зөвшөөрдөггүй байсан хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг хүлээн зөвшөөрөх тохиолдолд холбогдох тохируулгыг хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдэлд тайлагнана гэдгийг тусгайлан заасан шилжилтийн нэмэлт нөхцлүүдийг УСНББОУС 16-д тусгасан.
- УСНББОУС 16 нь зарим тохиолдолд НББОУС 40-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь УСНББОУС 16 дахь “санхүүгийн үр дүнгийн тайлан” гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. НББОУС 40 дэх адилтгах нэр томъёо нь “орлогын тайлан” юм.
- НББОУС 40-ийн хувьд “орлого” /revenue/ нэр томъёоноос илүү өргөн утгатай байдаг “орлого” /income/ нэр томъёог УСНББОУС 16-д ашигладаггүй.



## УСНББОУС 17–ҮНДСЭН ХӨРӨНГӨ

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) 16, *Үндсэн Хөрөнгө* (2003 онд хянан засварласан)-өөс үндсэндээ бэлтгэсэн болно. НББОУС 16-гаас авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон ЕС4М 6ХН, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)

Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.

## УСНББОУС 17-ҮНДСЭН ХӨРӨНГӨ

### УСНББОУС-ын түүх

Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

УСНББОУС 17, Үндсэн Хөрөнгө-ийг 2001 оны 12 дугаар сард гаргасан.

2006 оны 12 дугаар сард УСНББОУС3 нь хянан засварласан УСНББОУС 17-г гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 17-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл (2017 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 39, Ажилтны Тэтгэмж (2016 оны 7 дугаар сард гаргасан)
- Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт (УСНББОУС 21, Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт ба УСНББОУС 26, Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүд) (2016 оны 7 дугаар сард гаргасан)
- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2014-ийн Сайжруулалтууд (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 32, Үйлчилгээний Концессын Хэлцэл: Эрх бүхий этгээд (2011 оны 10 дугаар сард гаргасан)
- УСНББОУС 2011-ийн Сайжруулалтууд (2011 оны 10 дугаар сард гаргасан)
- УСНББОУС-ын Сайжруулалтууд (2010 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 27, Хөдөө Аж Ахуй (2009 оны 12 дугаар сард гаргасан)
- УСНББОУС 31, Биет Бус Хөрөнгө (2010 оны 01 дүгээр сард гаргасан)

### УСНББОУС 17-гийн нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт

Өөрчлөгдсөн параграф	Хэрхэн өөрчилсөн	Юугаар өөрчилсөн
Танилцуулга хэсэг	Хассан	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
3	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар

ҮНДСЭН ХӨРӨНГӨ

4	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
5	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 32, 2011 оны 10-р сар УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
6	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 27, 2009 оны 12-р сар УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
7	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 32, 2011 оны 10-р сар
8	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар
13	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
14	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
17	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2015 оны 01-р сар
20	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
31	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 39, 2016 оны 7-р сар
36А	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
50	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2015 оны 01-р сар
51А	Шинэ	Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт, 2016 оны 7-р сар
52	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
60	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
65	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 31, 2010 оны 01-р сар
72	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2015 оны 01-р сар
78А	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2015 оны 01-р сар
79	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
81	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
83	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
83А	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар
84	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар

ҮНДСЭН ХӨРӨНГӨ

88	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
93	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
95	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
96	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
97	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
98	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
99	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
100	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
101	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
102	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
103	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
104	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
106А	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2015 оны 01-р сар
107А	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар
107Б	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар
107В	Шинэ	УСНББОУС 32, 2011 оны 10-р сар
107Г	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
107Д	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2015 оны 01-р сар
107Е	Шинэ	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
107Ж	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
107И	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
107К	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
107Л	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
107М	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
107Н	Шинэ	Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт, 2016 оны 7-р сар
107О	Шинэ	УСНББОУС 39, 2016 оны 7-р сар
107П	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
108	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар

**УСНББОУС 17–ҮНДСЭН ХӨРӨНГӨ**

**АГУУЛГА**

	Параграф
Зорилго	1
Цар хүрээ	2-12
Соёлын өв хөрөнгө	9-12
Тодорхойлолт	13
Хүлээн зөвшөөрөлт	14-25
Дэд бүтцийн хөрөнгө	21
Анхдагч зардал	22
Дараа үеийн зардал	23-25
Хүлээн зөвшөөрөлтийн үеийн хэмжилт	26-41
Өртгийн элементүүд	30-36
Өртгийн хэмжилт	37-41
Хүлээн зөвшөөрөлтийн дараах хэмжилт	42-81
Өртгийн загвар	43
Дахин үнэлгээний загвар	44-58
Элэгдэл	59-78
Элэгдүүлэх дүн ба элэгдлийн хугацаа	66-75
Элэгдлийн арга	76-78
Үнэ цэнийн бууралт	79
Үнэ цэнийн бууралтын нөхөн төлбөр	80-81
Үл хүлээн зөвшөөрөлт	82-87
Тодруулга	88-94
Шилжилтийн нөхцөл	95-106
Хүчин төгөлдөр болох хугацаа	107-108
УСНББОУС 17 (2001)-гоос татгалзах	109
Хавсралт: Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт	
Дүгнэлтийн үндэслэл	
Хэрэгжүүлэх заавар удирдамж	
Үлгэрчилсэн жишээ	
НББОУС 16-тай харьцуулалт	

## ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 17, *Үндсэн Хөрөнгө*-ийг 1-109-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 17-г түүний зорилгын агуулга, Дүгнэлтийн Үндэслэл, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

1. Энэхүү Стандартын зорилго нь байгууллага өөрийн үндсэн хөрөнгөндөө хийсэн хөрөнгө оруулалт болон тэрхүү хөрөнгө оруулалтын өөрчлөлтийн талаархи мэдээллийг тухайн санхүүгийн тайлангийн хэрэглэгч нар олж авах боломжтой байдлаар үндсэн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн арга хандлагыг тодорхойлоход оршино. Үндсэн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн үндсэн асуудал нь (а) хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, (б) тэдгээрийн дансны үнийн тодорхойлолт, (в) хөрөнгөтэй холбоотойгоор хүлээн зөвшөөрөх элэгдлийн зардал ба үнэ цэнийн бууралтын гарз юм.

## Цар хүрээ

2. **Нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь доор дурдсанаас бусад тохиолдолд үндсэн хөрөнгийг тайлагнахдаа энэхүү Стандартыг мөрдөнө:**
  - (а) **Бусад УСНББОУС-ын дагуу нягтлан бодох бүртгэлийн өөр арга хандлагыг мөрдсөн; ба**
  - (б) **Өв хөрөнгө байх. Гэхдээ хүлээн зөвшөөрсөн тэдгээр өв хөрөнгүүдэд 88, 89, 92-р параграфын тодруулгын шаардлагуудыг мөрдөнө.**
3. [Хассан]
4. [Хассан]
5. Энэ Стандартыг дараах үндсэн хөрөнгөнд мөрдөнө:
  - (а) Зэвсгийн систем;
  - (б) Дэд бүтцийн хөрөнгө; ба
  - (в) УСНББОУС 32, *Үйлчилгээний Концессын Хэлцэл: Эрх бүхий этгээд*-ийн дагуу хийгдсэн анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийн дараах үйлчилгээний концессын хэлцлийн хөрөнгө.

95-104-р параграф дахь шилжилтийн нөхцүүд нь бүх үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрөх шаардлагуудаас таван жилийн шилжилтийн хугацааны туршид чөлөөлдөг.
6. Энэ Стандартыг дараах зүйлсэд мөрдөхгүй:
  - (а) Эх ургамлаас бусад хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой биологийн хөрөнгө (УСНББОУС 27, *Хөдөө Аж Ахуй*-г үзнэ үү). Энэ Стандартыг эх ургамалд мөрдөх боловч эх ургамлаас үүссэн бүтээгдэхүүнд мөрдөхгүй;
  - (б) Газрын тос, байгалийн хий болон эдгээртэй ижил төстэй үл нөхөн сэргээгдэх ашигт малтмалын нөөц ба ашигт малтмалын эрх (ашигт малтмалын эрх, ашигт малтмалын нөөц болон эдгээртэй ижил

## ҮНДСЭН ХӨРӨНГӨ

төстэй үл нөхөн сэргээгдэх ашигт малтмалын нөөцийн талаархи олон улсын буюу үндэсний холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартуудыг үзнэ үү).

Гэхдээ 6(а) эсвэл 6(б)-д дурдсан хөрөнгүүдийг эзэмших буюу боловсруулахад хэрэглэж буй үндсэн хөрөнгийн хувьд энэ Стандартыг мөрдөнө.

7. Бусад УСНББОУС нь энэ Стандартад зааснаас өөр хандлагад үндэслэн үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрөхөөр шаардаж болох юм. Жишээлбэл; УСНББОУС 13, *Түрээс* нь түрээслэсэн үндсэн хөрөнгийг тэдгээрийн эрсдэл ба урамшууллын шилжилтэнд үндэслэн хүлээн зөвшөөрөхийн тулд үнэлж үзэхийг байгууллагаас шаарддаг. УСНББОУС 32 нь үйлчилгээний концессын хэлцэлд ашиглаж буй үндсэн хөрөнгийг тухайн хөрөнгийн хяналтанд үндэслэн үнэлэхийг байгууллагаас шаарддаг. Гэвч ийм тохиолдолд тэдгээр хөрөнгүүдийн нягтлан бодох бүртгэлийн хандлагын бусад төлөв байдлуудыг, үүн дотроо элэгдлийг энэхүү Стандартаар тодорхойлно.
8. УСНББОУС 16, *Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө*-д заасны дагуу хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөндөө өртгийн загварыг ашигладаг байгууллага нь энэхүү Стандартад заасан өртгийн загварыг ашиглана.

### **Соёлын өв хөрөнгө**

9. Энэ Стандарт нь үндсэн хөрөнгийн тодорхойлолт ба хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангахгүй соёлын өв хөрөнгийг хүлээн зөвшөөрөхийг байгууллагаас шаардахгүй. Хэрэв байгууллага нь соёлын өв хөрөнгийг хүлээн зөвшөөрдөг бол энэ Стандартын тодруулгын шаардлагуудыг мөрдөх ёстой боловч энэ Стандартын хэмжилтийн шаардлагуудыг мөрдөх албагүй юм.
10. Зарим хөрөнгийг тэдгээрийн соёлын, байгаль орчны эсвэл түүхийн ач холбогдлоос хамааран соёлын өв хөрөнгө гэж тодорхойлдог. Соёлын өв хөрөнгийн жишээнд түүхэн байшин барилга, хөшөө дурсгал, археологийн олдворт газар, байгалийн цогцолборт газар, дархан цаазат газар, урлагийн бүтээл хамаарна. Соёлын өв хөрөнгө нь дараах гэх мэт ихэвчлэн тодорхой шинж чанаруудтай байдаг (гэхдээ эдгээр шинж чанарууд нь ийм хөрөнгөнд цор ганц байдаггүй):
  - (а) Тэдгээрийн соёлын, байгаль орчны болон түүхэн нөхцлөөр илэрхийлэгдэх үнэ цэнэ нь зах зээлийн үнэд зөвхөн үндэслэсэн санхүүгийн үнэ цэнээр бүрэн тусгагдах магадлал багатай байдаг;
  - (б) Хууль ба/буюу зохицуулалтын үүрэг нь тэдгээрийг борлуулж данснаас хасахыг хориглох буюу хатуу хязгаарлалт тогтоож болох юм;



## ҮНДСЭН ХӨРӨНГӨ

- (в) Тэдгээрийг ихэвчлэн орлуулах боломжгүй бөгөөд хэдийгээр тэдгээрийн биет чанар байдал муудан доройтох боловч цаг хугацааны явцад үнэ цэнэ нь өсдөг байж болно;
- (г) Тэдгээрийн ашиглалтын хугацааг тооцоолоход хүндрэлтэй бөгөөд зарим тохиолдолд хэдэн зуун жил байж болох юм.

Улсын секторын байгууллагууд нь худалдан авалт, хандив, гэрээслэл, улсын орлого болгон хураалт гэх мэт янз бүрийн арга замаар олон жилийн хугацаанд олж эзэмшсэн соёлын томоохон өв хөрөнгөтэй байж болох юм. Эдгээр хөрөнгийг мөнгөн орлого бий болгох тэдгээрийн чадвар боломжийн дагуу бараг эзэмшдэггүй бөгөөд ийм зорилгоор ашиглахад хуулийн буюу нийгмийн саад хязгаарлалттай байж болно.

- 11. Зарим соёлын өв хөрөнгө нь өөрийн өвийн үнэ цэнээс гадна ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхитай байдаг. Жишээлбэл; түүхэн барилгыг оффисын зориулалтаар ашиглаж болох юм. Энэ тохиолдолд түүнийг үндсэн хөрөнгийн бусад зүйлстэй ижил сууриар хүлээн зөвшөөрч, хэмжиж болно. Соёлын бусад өв хөрөнгийн хувьд тэдгээрийн ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь тэдгээр өвийн жишээлбэл; хөшөө дурсгал ба балгас туурийн шинж чанараас хамаардаг. Ирээдүйн эдийн засгийн үр өгөөж ба үйлчилгээний чадавхийн аль алины оршин байдал нь хэмжилтийн суурийн сонголтонд нөлөөлдөг.
- 12. 88-94-р параграфт дурдсан тодруулгын шаардлагууд нь тухайн хүлээн зөвшөөрсөн хөрөнгийн талаар тодруулга хийхийг байгууллагуудаас шаарддаг. Иймээс соёлын өв хөрөнгийг хүлээн зөвшөөрдөг байгууллагууд нь эдгээр хөрөнгүүдийн хувьд тухайлбал, дараах гэх мэт зүйлсийг тодруулах шаардлагатай байдаг:
  - (а) Ашигласан хэмжилтийн суурь;
  - (б) Хэрэв байгаа бол ашигласан элэгдлийн арга;
  - (в) Нийт дансны үнэ;
  - (г) Хэрэв байгаа бол тухайн тайлант үеийн эцсээрх хуримтлагдсан элэгдэл;
  - (д) Тайлант үеийн эхэн ба эцэс дэх дансны үнийн тодорхой бүрэлдэхүүн хэсгүүдийг харуулсан тохируулгын тайлан.

### Тодорхойлолт

- 13. **Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:**

**Эх ургамал гэдэг нь дараах амьд ургамлыг хэлнэ:**

- (а) **Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл буюу нийлүүлэлтэнд ашиглагддаг;**

- (б) Нэгээс дээш тайлант үеийн хувьд бүтээгдэхүүн өгөхөөр хүлээгдэж буй; ба
- (в) Тохиолдлын шинжтэйгээр хаягдал бүтээгдэхүүн байдлаар борлуулахаас бусад тохиолдолд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн гэдэг утгаар борлуулагдах магадлал багатай.

(Эх ургамлын энэхүү тодорхойлолтыг УСНББОУС 27-гийн 9А-9В параграфт илүү дэлгэрэнгүй заасан.)

Дансны үнэ гэдэг нь (энэхүү Стандартын зорилгын хувьд) нь аливаа хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнэ бууралтын гарзыг хассаны дараах хөрөнгийг хүлээн зөвшөөрч байгаа дүн юм.

Үндсэн хөрөнгийн анги гэдэг нь байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах байдлын хувьд ижил төсөөтэй шинж төрөл, чиг үүрэгтэй бөгөөд санхүүгийн тайланд толилуулах зорилгоор нэг ганц зүйл байдлаар харуулдаг хөрөнгүүдийн бүлэг юм.

Элэгдүүлэх дүн гэдэг нь хөрөнгийн өртгөөс эсвэл өртгийг орлох бусад дүнгээс түүний үлдэх өртгийг хассан дүнг хэлнэ.

Элэгдэл гэдэг нь хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид хуваарилах системтэй хуваарилалт юм.

Байгууллагын тусгайлсан үнэ цэнэ гэдэг нь хөрөнгийн тасралтгүй ашиглалтаас болон түүний ашиглалтын хугацааны эцэс дэх данснаас хасалтаас үүсэхээр эсвэл өр төлбөрийг барагдуулах үед зарцуулахаар уг байгууллагын хүлээж буй мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ юм.

Мөнгө бий болгогч хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз гэдэг нь хөрөнгийн дансны үнэ өөрийн нөхөгдөх дүнгээс давж илүү гарсан дүн юм.

Мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз гэдэг нь хөрөнгийн дансны үнэ өөрийн нөхөгдөх дүнгээс давж илүү гарсан дүн юм.

Үндсэн хөрөнгө гэдэг нь дараах шинжтэй биет зүйлсийг хэлнэ. Үүнд:

- (а) Бараа, үйлчилгээний үйлдвэрлэл буюу нийлүүлэлтэнд ашиглах, бусдад түрээслэх эсвэл удирдлагын хэрэгцээнд ашиглах зорилгоор эзэмшиж байгаа; ба
- (б) Нэгээс дээш тайлант үед ашиглагдахаар хүлээгдэж буй.

Нөхөгдөх дүн гэдэг нь хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ ба түүний ашиглалтын үнэ цэнийн аль өндөр дүн юм.

Нөхөгдөх үйлчилгээний дүн гэдэг нь мөнгө бий болгодоггүй хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ ба түүний ашиглалтын үнэ цэнийн аль өндөр нь юм.

Хөрөнгийн үлдэх өртөг гэдэг нь хэрэв хөрөнгө ашиглагдаж, насжилттай болвол түүний ашиглалтын хугацааны эцэст хүлээгдэж буй тэрхүү нөхцөл байдалд хөрөнгийг данснаас хасахтай холбоотой тооцоолсон зардлыг хассаны дараа тухайн байгууллага уг хөрөнгийн данснаас хасалтаар одоо хүлээн авах тооцоолсон дүн юм.

Ашиглалтын хугацаа гэдэг нь:

- (a) Байгууллагад уг хөрөнгө ашиглагдах боломжтой байхаар хүлээгдэж буй хугацаа; эсвэл
- (б) Байгууллага тухайн хөрөнгөөс олж авахаар хүлээгдэж буй бүтээгдэхүүн буюу түүнтэй ижилт төсөөтэй нэгжүүдийн тоо хэмжээ.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д дахин нийтэлсэн болно.

## Хүлээн зөвшөөрөлт

- 14. Үндсэн хөрөнгийн өртгийг зөвхөн дараах тохиолдолд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө:
  - (a) Тухайн хөрөнгөтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь тухайн байгууллагад орох нилээд их магадлалтай байх; ба
  - (б) Тухайн хөрөнгийн өртөг буюу үйлчилгээний чадавхийг найдвартай хэмжиж чадах.<sup>1</sup>
- 15. [Хассан]
- 16. [Хассан]
- 17. Сэлбэг, нөөцөнд байгаа тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ хийгдэж буй тоног төхөөрөмж гэх мэт зүйлс нь үндсэн хөрөнгийн тодорхойлолтыг хангасан тохиолдолд энэ УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрнө. Ингэж хангаагүй тохиолдолд эдгээр зүйлсийг бараа материал гэж ангилна.

---

<sup>1</sup> Найдвартай мэдээлэл нь материаллаг алдаа ба туйлшралаас ангид байх бөгөөд өөрийн илэрхийлэхээр зориулагдсан буюу илэрхийлнэ гэж ул үндэслэлтэйгээр хүлээж болох зүйлсийг үнэн зөв илэрхийлэхдээ хэрэглэгчдээс хамаардаг байж болох юм. Найдвартай байдлын тайлбарын талаархи шилжилтийн арга хандлагыг УСНББОУС 1-ийн ДҮ16-р параграфт авч хэлэлцсэн.

18. Энэ Стандарт нь хүлээн зөвшөөрөлтөнд зориулсан хэмжилтийн нэгжийг, өөрөөр хэлбэл үндсэн хөрөнгийн зүйлсийг юу бүрдүүлэхийг зааж өгөөгүй. Иймээс байгууллагын тухайн тодорхой нөхцөл байдалд хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хэрэглэхдээ шүүн тунгаалт хийх шаардлагатай. Номын сангийн ном, компьютерийн дагалдах хэрэгсэл, жижиг багаж хэрэгсэл гэх мэт тус тусдаа том биш зүйлсийг нэгтгэн нийлүүлэх ба тэрхүү нэгтгэн нийлүүлсэн үнэ цэнэд уг шалгуурыг хэрэглэх нь тохиромжтой байж болох юм.
19. Энэхүү хүлээн зөвшөөрөлтийн зарчмын дагуу байгууллага нь өөрийн бүх үндсэн хөрөнгийн өртөг зардлыг тэдгээрийн гарсан тэрхүү цаг хугацаанд үнэлнэ. Эдгээр өртөг зардал нь үндсэн хөрөнгийн зүйлсийг худалдан авах буюу барьж байгуулахад анх гарсан өртөг зардал болон хөрөнгөнд тодорхой хэсгийг нэмэх, заримыг сольж орлуулах буюу засвар үйлчилгээ хийхэд дараа гарсан өртөг зардлуудаас бүрдэнэ.
20. Зэвсгийн систем нь үндсэн хөрөнгийн тодорхойлолтыг ихэвчлэн хангадаг бөгөөд түүнийг энэхүү Стандартын дагуу хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Энхийн цагт зөвхөн сүр хүчийг үзүүлэх зорилгоор ашигладаг боловч батлан хамгаалах үйлчилгээнд байнга ашиглагдах байлдааны хөлөг онгоц, шумбагч, цэргийн нисэх онгоц, танк, пуужин тээвэрлэгч, хөөргөх систем гэх мэт тээвэрлэгч хэрэгсэл болон бусад тоног төхөөрөмж нь зэвсгийн системд хамаардаг. Зарим төрлийн тив алгасагч пуужин гэх мэт зөвхөн нэг удаа ашиглагдах зүйлс нь өдөөн хатгагч талын эсрэг сүр хүчийг байнга үзүүлэхэд ашиглагдах тул тэдгээрийг зэвсгийн систем гэж ангилж болно.

### **Дэд бүтцийн хөрөнгө**

21. Зарим хөрөнгийг ерөнхийдөө дэд бүтцийн хөрөнгө гэж тодорхойлдог. Дэд бүтцийн хөрөнгийн талаархи нийтээр хүлээн зөвшөөрсөн тодорхойлолт байхгүй боловч эдгээр хөрөнгүүд нь ихэвчлэн дараах бүх буюу зарим шинж чанартай байдаг:
  - (а) Эдгээр нь систем буюу сүлжээний нэг хэсэг байх;
  - (б) Эдгээр нь тусгайлсан шинж төрөлтэй бөгөөд өөр хувилбараар ашиглах боломжгүй байх;
  - (в) Эдгээр нь хөдлөх шинжтэй байх; ба
  - (г) Тэдгээрийг данснаас хасахад саад хязгаарлалттай байж болох юм.

Дэд бүтцийн хөрөнгийн өмчлөл нь улсын секторын байгууллагуудаар хязгаарлагдахгүй боловч улсын секторт ихэвчлэн томоохон дэд бүтцийн хөрөнгүүд байдаг. Дэд бүтцийн хөрөнгө нь үндсэн хөрөнгийн тодорхойлолтыг хангах бөгөөд түүнийг энэхүү Стандартын дагуу тайлагнах хэрэгтэй. Дэд бүтцийн хөрөнгийн жишээнд авто замын сүлжээ, бохир зайлуулах систем, усны болон цахилгаан хангамжийн систем, харилцаа холбооны сүлжээ хамаардаг.

**Анхдагч зардал**

22. Үндсэн хөрөнгийн зүйлсийг аюулгүй байдал эсвэл байгаль орчны учир шалтгаанаар олж эзэмшиж болно. Ийм үндсэн хөрөнгийн олж бэлтгэлт нь одоо байгаа аливаа нэг үндсэн хөрөнгийн зүйлийн ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг шууд нэмэгдүүлдэггүй боловч тухайн байгууллага өөрийн бусад хөрөнгөөс ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи олж авахад зайлшгүй шаардлагатай байж болно. Хэрэв эдгээр хөрөнгийг олж эзэмшээгүй бол олох байсан өгөөжөөс илүү давсан ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг тэдгээрийн холбогдох хөрөнгүүдээс олох боломжийг тухайн байгууллагад олгодог учраас ийм үндсэн хөрөнгийн зүйлс нь хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангах юм. Жишээлбэл; галын аюулгүй байдлын дүрэм нь шинэ гал унтраагуурын систем суурилуулахыг эмнэлгээс шаардаж болох юм. Ийм системгүй бол тухайн байгууллага өөрийн эмнэлгийг дүрмийн дагуу эрхлэн ажиллуулах боломжгүй учраас тэрхүү сайжруулалтыг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө. Гэхдээ ийм хөрөнгө болон холбоотой хөрөнгүүдийн дансны үнэд үнэ цэнийн бууралт гарсан эсэхийг УСНББОУС 21, *Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-ын дагуу нягталж шалгана.

**Дараа үеийн зардал**

23. 14-р параграфт заасан хүлээн зөвшөөрөлтийн зарчмын дагуу байгууллага нь үндсэн хөрөнгийн зүйлийн өдөр тутмын үйлчилгээний зардлыг түүний дансны үнэд хүлээн зөвшөөрдөггүй. Харин эдгээр зардлыг гарсан үед нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Өдөр тутмын үйлчилгээний зардал нь үндсэндээ хөдөлмөрийн болон хангамжийн зүйлсийн зардал байх бөгөөд үүнд жижиг сэлбэг хэрэгслийн зардал хамаарч болох юм. Эдгээр зарлагыг ихэвчлэн үндсэн хөрөнгийн “засвар үйлчилгээ”-ний зориулалттай гэж тодорхойлдог.
24. Зарим үндсэн хөрөнгийн зүйлсийн тодорхой хэсгийг тогтоосон хугацааны мужаар сольж орлуулах шаардлагатай байж болно. Жишээлбэл; авто замд хэдэн жил тутамд замын хучлага тавих, зуухыг тогтоосон тооны цаг ашигласны дараа хөөлж цэвэрлэх эсвэл суудал, хоолны хэсэг гэх мэт онгоцны дотоод хэсгийг тухайн онгоцны ашиглалтын хугацаанд хэд хэдэн удаа солих шаардлагатай байж болно. Барилгын дотор ханыг солих гэх мэт цөөн давтагдах эсвэл дахин үл давтагдах орлуулалт хийх тийм үндсэн хөрөнгийн зүйлсийг мөн олж бэлтгэж болох юм. 14-р параграфт заасан хүлээн зөвшөөрөлтийн зарчмын дагуу, байгууллага нь ийм зүйлсийн орлуулан нэмэгдэж буй хэсгийг хэрэв хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангаж байвал тухайн өртөг зардал гарсан үед үндсэн хөрөнгийн дансны үнэд оруулан хүлээн зөвшөөрнө. Харин орлуулагдан хасагдаж буй хэсгийн дансны үнийг энэхүү Стандартын үл хүлээн зөвшөөрөлтийн нөхцлийн дагуу үл хүлээн зөвшөөрнө (82-87-р параграфыг үзнэ үү).

25. Үндсэн хөрөнгийн зүйлийг (жишээлбэл, нисэх онгоц) тасралтгүй ашиглан ажиллуулах нөхцөл нь тухайн зүйлийн тодорхой хэсгийг сольж орлуулах эсэхээс үл хамааран эвдрэл гэмтлийн хувьд ерөнхий үзлэг шалгалтыг тогтмол хийдэг байж болох юм. Ерөнхий үзлэг шалгалт нэг бүрийг гүйцэтгэх үед түүний өртөг нь хэрэв хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангаж байвал орлуулалттай нэгэн адилаар үндсэн хөрөнгийн зүйлсийн дансны үнэд хүлээн зөвшөөрнө. Өмнөх үзлэг шалгалтын өртгөөс үлдсэн аливаа дансны үнийг (биет хэсгүүдэд хамааралгүй) үл хүлээн зөвшөөрнө. Тухайн үндсэн хөрөнгийн зүйлийг олж бэлтгэсэн буюу барьж байгуулсан ажил гүйлгээгээр тэрхүү өмнөх үзлэг шалгалтын өртгийг тодорхойлсон эсэхээс үл хамааран ингэж үл хүлээн зөвшөөрөх буюу данснаас хасдаг. Хэрэв шаардлагатай бол, ирээдүйн ижил төсөөтэй үзлэг шалгалтын тооцоолсон өртгийг тухайн үндсэн хөрөнгийн зүйлийг олж бэлтгэх буюу барьж байгуулах үед одоогийн үзлэг шалгалтын бүрэлдэхүүн хэсгийн өртөг зардал ямар байх байсныг илэрхийлэх үзүүлэлт болгон ашиглаж болно.

### **Хүлээн зөвшөөрөлтийн үеийн хэмжилт**

26. **Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж буй үндсэн хөрөнгийн зүйлийг түүний өртгөөр хэмжинэ.**
27. **Хөрөнгийг арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн тохиолдолд түүний өртгийг тэрхүү олж эзэмшилтийн өдрөөрх бодит үнэ цэнээр нь хэмжинэ.**
28. Үндсэн хөрөнгийн зүйлийг арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшиж болно. Жишээлбэл; хөгжүүлэгч нь уг хөгжүүлэлтэнд хамаарах парк, авто зам болон явган хүний замыг хөгжүүлэх боломжийг орон нутгийн засаг захиргаанд олгохын тулд үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр газрыг тухайн орон нутгийн засаг захиргаанд өгч болох юм. Улсын орлого болгон хураах бүрэн эрхийг хэрэгжүүлснээр хөрөнгийг мөн арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшиж болно. Ийм нөхцөлд тухайн зүйлийн өртөг нь уг зүйлийг олж эзэмшсэн өдрөөрх түүний бодит үнэ цэнэ байна.
29. Энэ Стандартын зорилгын хувьд, үнэгүй буюу нэрлэсэн өртгөөр олж эзэмшсэн үндсэн хөрөнгийн зүйлийг 27-р параграфын шаардлагад нийцүүлэн түүний бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх хэмжилт нь дахин үнэлгээг орлохгүй юм. Иймээс байгууллага нь үндсэн хөрөнгийн зүйлийг дараагийн тайлант үед дахин үнэлэх сонголт хийсэн зөвхөн тийм тохиолдолд 44-р параграфт заасан, дахин үнэлгээний шаардлагууд болон 45-50-р параграфт дурдсан, дэмжих тайлбарыг даган мөрдөнө.

**Өртгийн элементүүд**

30. Үндсэн хөрөнгийн зүйлийн өртөг нь дараах зүйлсээс бүрдэнэ:
- (а) Худалдааны хөнгөлөлт ба үнийн бууралтыг хассаны дараах худалдан авалтын үнэ, үүнд импортын татвар ба буцаан үл олгогдох худалдан авалтын татварууд.
  - (б) Удирдлагын төлөвлөсөн арга маягаар ажиллуулах боломжтой болгоход шаардлагатай тийм байршил болон нөхцөл байдалд уг хөрөнгийг авчрахад шууд хамааралтай аливаа өртөг зардал.
  - (в) Үндсэн хөрөнгийн зүйлийг буулгаж задлах, холдуулж зайлуулах ба түүний байрлаж байсан газар талбайг хэвийн байдалд оруулах өртөг зардлын, түүнчлэн уг зүйлийг олж бэлтгэх үед эсвэл тухайн хугацааны туршид бараа материал үйлдвэрлэхээс өөр бусад зорилгоор түүнийг тодорхой хугацаанд ашигласны үр дүнд байгууллагын хүлээх үүргийн анхны тооцоолсон дүн.
31. Шууд хамааралтай өртөг зардлын жишээ нь;
- (а) Үндсэн хөрөнгийн зүйлийг барьж байгуулах буюу худалдан авахтай шууд холбогдон гарсан ажилтны тэтгэмжийн зардал (УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-д тодорхойлсоны дагуу);
  - (б) Газар талбайг бэлтгэх зардал;
  - (в) Анхны хүргэлт ба ачиж, буулгах зардал;
  - (г) Суурилуулалт ба угсралтын зардал;
  - (д) Хөрөнгийг тухайн байршил болон нөхцөл байдалд авчрах явцад үйлдвэрлэсэн аливаа зүйлс (тоног төхөөрөмжийг сорьж турших үед үйлдвэрлэсэн дээж бүтээгдэхүүн)-ийг борлуулснаар олсон цэвэр орлогыг хассаны дараах, уг үндсэн хөрөнгө зохих ёсоор ажиллаж буй эсэхийг сорьж шалгах зардал; ба
  - (е) Мэргэжлийн үйлчилгээний хөлс.
32. Байгууллага нь тухайн хугацааны туршид бараа материал үйлдвэрлэхийн тулд уг үндсэн хөрөнгийн зүйлийг ашигласны үр дүнд тодорхой хугацаанд гаргасан, үндсэн хөрөнгийн зүйлийг буулгаж задлах, холдуулж зайлуулах ба түүний байрлаж байсан газар талбайг хэвийн байдалд оруулах үүрэгтэй холбоотой өртөг зардлын хувьд УСНББОУС 12, *Бараа Материал*-ыг дагаж мөрдөнө. УСНББОУС 12 ба УСНББОУС 17-гийн дагуу бүртгэж тайлагнасан өртөг зардлуудын холбогдох өр төлбөрийг УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-ийн дагуу хүлээн зөвшөөрч, хэмжинэ.
33. Үндсэн хөрөнгийн өртөгт орохгүй өртөг зардлын жишээ нь;
- (а) Шинэ үйлдвэр нээх зардал;

## ҮНДСЭН ХӨРӨНГӨ

- (б) Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг танилцуулах зардал (үүнд зар сурталчилгаа ба урамшууллын үйл ажиллагааны зардал хамаарна);
  - (в) Шинэ байрлалд эсвэл шинэ хэрэглэгчидтэй бизнес хийхэд гарах зардал (үүнд ажилтнуудын сургалтын зардал хамаарна); ба
  - (г) Захиргааны болон бусад ерөнхий удирдлагын нэмэгдэл зардал.
34. Удирдлагын төлөвлөсөн арга маягаар ажиллуулах боломжтой болгоход шаардлагатай тийм байршил болон нөхцөл байдалд уг хөрөнгийг авчирсан тохиолдолд өртөг зардлыг тухайн үндсэн хөрөнгийн дансны үнэд хүлээн зөвшөөрөхийг зогсооно. Иймээс үндсэн хөрөнгийн зүйлийг ашиглах эсвэл өөр байршилд шилжүүлэхэд гаргасан өртөг зардлыг тухайн хөрөнгийн зүйлийн дансны үнэд оруулахгүй. Тухайлбал; дараах өртөг зардлуудыг үндсэн хөрөнгийн зүйлийн дансны үнэд тусган оруулахгүй:
- (а) Удирдлагын төлөвлөсөн арга маягаар ажиллуулах боломжтой болсон хөрөнгийн зүйл нь ашиглалтанд хараахан ороогүй байгаа эсвэл бүрэн хүчин чадлаас бага хүчин чадлаар ажиллах үед гарсан өртөг зардал;
  - (б) Тухайн хөрөнгийн зүйлээр үйлдвэрлэх бүтээгдэхүүний эрэлт бий болох явцад гарсан өртөг зардал гэх мэт үйл ажиллагааны эхлэлийн шатны алдагдал; ба
  - (в) Байгууллагын бүх буюу зарим үйл ажиллагааг дахин байршуулах эсвэл дахин зохион байгуулах өртөг зардал.
35. Зарим үйл ажиллагаа нь үндсэн хөрөнгийн зүйлийг барьж байгуулах эсвэл хөгжүүлэхтэй холбоотойгоор гарч тохиолддог боловч удирдлагын төлөвлөсөн арга маягаар ажиллуулах боломжтой болгоход шаардлагатай тийм байршил болон нөхцөл байдалд уг хөрөнгийг авчрахад зайлшгүй шаардлагатай биш байдаг. Ийм туслах үйл ажиллагаа нь барьж байгуулах буюу хөгжүүлэх үе шатны явцад эсвэл түүнээс өмнө гарч тохиолдож болох юм. Жишээлбэл; барилгын ажил эхлэх хүртэл барилгын талбайг автомашины зогсоол байдлаар ашигласнаар орлого олж болно. Энэхүү туслах үйл ажиллагаа нь удирдлагын төлөвлөсөн арга маягаар ажиллуулах боломжтой болгоход шаардлагатай тийм байршил болон нөхцөл байдалд уг хөрөнгийг авчрахад зайлшгүй шаардлагатай биш тул ийм туслах үйл ажиллагааны орлого болон холбогдох зардлыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрч, тэдгээр орлого, зардлын тус тусын ангилалд хамааруулан тусгана.
36. Өөрөө барьж байгуулсан хөрөнгийн өртгийг тодорхойлохдоо худалдаж авсан хөрөнгийн өртгийг тодорхойлоход мөрддөгтэй адил зарчим баримтална. Хэрэв байгууллага нь хэвийн үйл ажиллагааны явцад борлуулдаг хөрөнгөтэй ижил төстэй хөрөнгийг өөрөө барьж байгуулдаг бол тийм хөрөнгийн өртөг нь борлуулах зорилгоор барьж байгуудаг хөрөнгийн өртөгтэй ихэвчлэн ижил байна (УСНББОУС 12-ыг үзнэ үү). Иймээс тэдгээр хөрөнгийн өртгийг тооцож, гаргахдаа аливаа дотоод ашгийг хасаж устгадаг. Үүнтэй адилаар, хөрөнгийг өөрөө барьж байгуулах



үед гарсан хаягдал материал, хөдөлмөрийн зардал буюу бусад нөөцийн хэвийн бус дүн бүхий өртөг зардлыг тухайн хөрөнгийн өртөгт оруулахгүй. УСНББОУС 5, *Зээлийн Өртөг* нь өөрөө барьж байгуулсан үндсэн хөрөнгийн зүйлийн дансны үнийн бүрэлдэхүүн хэсэг байдлаар хүүний зардлыг хүлээн зөвшөөрөх шалгуурыг тогтоосон байдаг.

- 36А. Удирдлагын төлөвлөсөн арга маягаар ажиллуулах боломжтой болгоход шаардлагатай тийм байршил болон нөхцөл байдалд эх ургамлыг авчрахаас өмнө, түүнийг өөрөө барьж байгуулсан үндсэн хөрөнгийн зүйлтэй ижил арга замаар бүртгэж тайлагнана. Иймээс удирдлагын төлөвлөсөн арга маягаар ажиллуулах боломжтой болгоход шаардлагатай тийм байршил болон нөхцөл байдалд эх ургамлыг авчрахаас өмнө түүнийг тарьж ургуулахад шаардлагатай үйл ажиллагааг энэ Стандарт дахь 'барьж байгуулах' гэсэн нэр томъёонд хамааруулна гэж ойлгож, уншвал зохино.

### Өртгийн хэмжилт

37. Үндсэн хөрөнгийн зүйлийн өртөг нь тухайн хүлээн зөвшөөрөлтийн өдөр дэх мөнгөн үнэтэй адилтгах дүн, харин 27-р параграфт дурдсан зүйлсийн хувьд түүний бодит үнэ цэнэ байна. Хэрэв төлбөрийг зээлийн хэвийн хугацаанаас илүүгээр хойшлуулвал тэрхүү мөнгөн үнэтэй адилтгах дүн ба нийт төлбөрийн хоорондох зөрүүг УСНББОУС 5-д заасан, зөвшөөрөгдсөн сонголтот хувилбарын дагуу тухайн зүйлийн дансны үнэд хүлээн зөвшөөрөхөөс бусад тохиолдолд уг зээлийн хугацаанд хүүний зардал гэж хүлээн зөвшөөрнө.
38. Мөнгөн зүйлийн бус хөрөнгө буюу хөрөнгүүдээр, эсвэл мөнгөн хөрөнгө ба мөнгөн зүйлийн бус хөрөнгийн аль алиныг оруулцуулсан солилцооны үр дүнд нэг буюу хэд хэдэн үндсэн хөрөнгийн зүйлийг олж авч болно. Дараах хэлэлцүүлэг нь нэг мөнгөн зүйлийн бус хөрөнгийг өөр нэг мөнгөн зүйлийн бус хөрөнгөөр солилцох хялбар жишээнд хамаарах боловч өмнөх өгүүлбэрт дурдсан бүх солилцооны хувьд үүнийг мөн баримтлах юм. Солилцоогоор олж эзэмшсэн үндсэн хөрөнгийн зүйлийг доор дурдсанаас бусад тохиолдолд бодит үнэ цэнээр хэмжинэ. Үүнд: (а) солилцооны ажил гүйлгээ нь худалдаа арилжааны шинж чанаргүй байх, (б) солилцоогоор хүлээн авсан болон өгсөн аль аль хөрөнгийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй байх. Байгууллага нь өгч буй хөрөнгөө тэр даруй үл хүлээн зөвшөөрөх буюу данснаас хасах боломжгүй байлаа ч гэсэн тухайн олж эзэмшсэн хөрөнгийг дээр дурдсан байдлаар хэмжинэ. Хэрэв хүлээн авсан хөрөнгийг түүний бодит үнэ цэнээр хэмжих боломжгүй байвал түүний өртгийг уг өгсөн хөрөнгийн дансны үнээр хэмжиж бүртгэнэ.
39. Байгууллага нь тухайн ажил гүйлгээний үр дүнд түүний ирээдүйн мөнгөн гүйлгээ эсвэл үйлчилгээний чадавхи өөрчлөгдөхөөр хүлээгдэж буй хэмжээг харгалзан үзэх замаар уг солилцооны ажил гүйлгээ нь худалдаа арилжааны шинж чанартай эсэхийг тодорхойлдог. Солилцооны ажил гүйлгээ нь дараах тохиолдолд худалдаа арилжааны шинж чанартай байна:

- (а) Хүлээн авсан хөрөнгийн мөнгөн гүйлгээ буюу үйлчилгээний чадавхийн төлөв байдал (эрсдэл, цаг хугацаа, дүн) нь шилжүүлэн өгсөн хөрөнгийн мөнгөн гүйлгээ буюу үйлчилгээний чадавхийн төлөв байдлаас ялгаатай байх;
- (б) Ажил гүйлгээгээр нөлөө үзүүлэх уг байгууллагын үйл ажиллагааны тодорхой нэг хэсгийн тухайн байгууллагын тусгайлсан үнэ цэнэ нь тэрхүү солилцооны үр дүнд өөрчлөгдөх; ба
- (в) дээрх (а) буюу (б)-д дурдсан зөрүү нь тухайн солилцсон хөрөнгүүдийн бодит үнэ цэнэтэй харьцуулахад мэдэгдэхүйц дүнтэй байх.

Солилцооны ажил гүйлгээ нь худалдаа арилжааны шинж чанартай эсэхийг тодорхойлох зорилгоор, ажил гүйлгээгээр нөлөө үзүүлэх уг байгууллагын үйл ажиллагааны тодорхой нэг хэсгийн тухайн байгууллагын тусгайлсан үнэ цэнэ нь хэрэв татвар хамааралтай бол татварын дараах мөнгөн гүйлгээг тусгасан байна. Худалдаа арилжааны шинж чанартай эсэхийг тодорхойлох шинжилгээ нь уг байгууллага нарийвчилсан тооцоолол хийгээгүй байхад тодорхой, ойлгомжтой байж болно.

- 40. Зах зээлийн зэрэгцүүлэгдэх ажил гүйлгээ байхгүй хөрөнгийн бодит үнэ цэнийг дараах тохиолдолд найдвартай хэмжих боломжтой байдаг. Үүнд:
  - (а) бодит үнэ цэнийн ул үндэслэлтэй хэмжилтийн муж доторх хувьсан өөрчлөлт нь тухайн хөрөнгийн хувьд мэдэгдэхүйц дүнтэй биш байх, эсвэл
  - (б) тухайн мужийн доторх өөр өөр тооцооллуудын магадлалыг ул үндэслэлтэйгээр үнэлэх ба бодит үнэ цэнийг хэмжих үед тэдгээрийг ашиглах боломжтой байх. Байгууллага нь солилцоогоор хүлээн авсан хөрөнгө эсвэл өгсөн хөрөнгийн аль алины бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадах тохиолдолд хүлээн авсан хөрөнгийн бодит үнэ цэнэ нь илүү тодорхой биш л бол тэрхүү хүлээн авсан хөрөнгийн өртгийг хэмжихийн тулд өгсөн хөрөнгийн бодит үнэ цэнийг ашиглана.
- 41. Санхүүгийн түрээсээр түрээслэгчийн эзэмшиж буй үндсэн хөрөнгийн өртгийг УСНББОУС 13-ын дагуу тодорхойлно.

### **Хүлээн зөвшөөрөлтийн дараах хэмжилт**

- 42. **Байгууллага нь 43-р параграфт заасан өртгийн загвар эсвэл 44-р параграфт заасан дахин үнэлгээний загварын аль нэгийг өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлого болгон сонгох бөгөөд тэрхүү бодлогыг үндсэн хөрөнгийн нийт ангийн хувьд мөрдөнө.**

### **Өртгийн загвар**

- 43. **Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа, үндсэн хөрөнгийн зүйлийг өртгөөс түүний аливаа хуримтлагдсан элэгдэл ба аливаа хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр бүртгэж, тусгана.**

**Дахин үнэлгээний загвар**

44. **Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа, бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжиж чадах үндсэн хөрөнгийн зүйлийг түүний дахин үнэлсэн дүнгээр бүртгэж, тусгана. Энэ нь дахин үнэлгээний өдрөөрх хөрөнгийн бодит үнэ цэнээс дараагийн тайлант үеийн аливаа хуримтлагдсан элэгдэл ба дараагийн тайлант үеийн хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн байна. Тайлангийн өдрөөрх бодит үнэ цэнийг ашигласнаар тодорхойлсон дүнгээс дансны үнэ нь материаллаг зөрүүгүй гэдгийг ханган магадлахын тулд дахин үнэлгээг хангалттай тогтмол хийдэг байвал зохино.**
45. Үл хөдлөх хөрөнгийн зүйлийн бодит үнэ цэнийг ихэвчлэн зах зээлд суурилсан нотолгооны дагуу үнэлгээгээр тодорхойлдог. Үндсэн хөрөнгийн зүйлсийн бодит үнэ цэнэ нь үнэлгээгээр ихэвчлэн тодорхойлсон тэдгээрийн зах зээлийн үнэ цэнэ байдаг. Мэргэжлийн хүлээн зөвшөөрөгдсөн зохих ур чадвартай үнэлгээний мэргэжилтэн нь хөрөнгийн үнэ цэнийн үнэлгээг ихэвчлэн гүйцэтгэдэг. Олон хөрөнгийн хувьд идэвхитэй ба хөрвөх зах зээл дэх жишиг үнийг лавлагаа болгосноор бодит үнэ цэнийг шууд тодорхойлох боломжтой байдаг. Жишээлбэл; газар, тусгай зориулалтын бус барилга, тээврийн хэрэгсэл болон олон төрлийн үндсэн хөрөнгийн хувьд одоогийн зах зээлийн үнийг ихэвчлэн олж авах боломжтой байдаг.
46. Улсын секторын зарим хөрөнгийн хувьд тэдгээр хөрөнгөнд хамаарах зах зээлийн ажил гүйлгээ байхгүйн улмаас зах зээлийн үнийг тогтооход төвөгтэй байж болох юм. Улсын секторын зарим байгууллагууд нь ийм томоохон хөрөнгүүдийг эзэмшдэг байж болно.
47. Үл хөдлөх хөрөнгийн идэвхитэй ба хөрвөх зах зээл дэх зах зээлийн үнэ цэнийг тодорхойлох нотолгоо бэлэн боломжтой байхгүй бол адилтгах нөхцөл ба байршил дахь ижил төсөөтэй шинж чанар бүхий бусад зүйлсийг лавлагаа болгосноор тухайн зүйлийн бодит үнэ цэнийг тодорхойлж болно. Жишээлбэл; урт хугацаагаар эзэмшиж байгаа бөгөөд тухайн хугацааны туршид цөөн ажил гүйлгээ гарсан засгийн газрын сул чөлөөтэй газрын бодит үнэ цэнийг зах зээлийн нотолгоо нь бэлэн боломжтой байгаа бөгөөд түүнтэй ижил төсөөтэй шинж чанартай ба адилтгах байршил дахь байр зүй бүхий газрын зах зээлийн үнэ цэнийг лавлагаа болгосноор тооцоолж болох юм. Тусгай зориулалтын барилга болон хүн хийж бүтээсэн бусад байгууламжийн хувьд элэгдүүлэх орлуулалтын өртөг, сэргээн босголтын өртөг, үйлчилгээний нэгжийн хандлагыг ашигласнаар бодит үнэ цэнийг тооцоолж болно (УСНББОУС 21-ийг үзнэ үү). Олон тохиолдолд, хөрөнгийн элэгдүүлэх орлуулалтын өртгийг тухайн идэвхитэй ба хөрвөх зах зээл дэх ижил төсөөтэй үлдсэн үйлчилгээний чадавхи бүхий адилтгах хөрөнгийн худалдан авалтын үнийг лавлагаа болгосноор тогтоодог. Зарим тохиолдолд хөрөнгийг дахин үйлдвэрлэн бий болгох өртөг нь түүний орлуулалтын өртгийн хамгийн сайн илэрхийлэгч байдаг. Жишээлбэл; нурж сүйрсэн тохиолдолд түүний нийгмийн ач холбогдлыг

## ҮНДСЭН ХӨРӨНГӨ

харгалзан парламентын барилгыг адилтгах орон байраар сольж орлуулахын оронд дахин барьж байгуулж болох юм.

48. Үндсэн хөрөнгийн зүйлийн тусгайлсан шинж чанарын улмаас түүний бодит үнэ цэнийн талаархи зах зээлд суурилсан нотолгоо байхгүй тохиолдолд байгууллага нь тухайлбал, дахин үйлдвэрлэн бий болгох өртөг, элэгдүүлэх орлуулалтын өртөг, үйлчилгээний нэгжийн хандлагыг ашигласнаар бодит үнэ цэнийг тооцоолох шаардлагатай байж болох юм (УСНББОУС 21-ийг үзнэ үү). Тухайн хөрөнгийг үйлдвэрлэн бий болгохын тулд ашиглах бүрдэл хэсгүүдийн худалдан авалтын зах зээлийн үнэ эсвэл ижил буюу төсөөтэй хөрөнгийн өмнөх тайлант үеийн үнэд үндэслэн индексжүүлсэн үнийг лавлагаа болгосноор үндсэн хөрөнгийн зүйлийн элэгдүүлэх орлуулалтын өртгийг тогтоож болно. Индексжүүлсэн үнийн аргыг ашиглах тохиолдолд үйлдвэрлэлийн технологи тухайн тайлант үеийн туршид мэдэгдэхүйц өөрчлөгдсөн эсэх, лавлагаа болгож буй хөрөнгийн хүчин чадал нь тухайн үнэлж буй хөрөнгөтэй ижил эсэхийг тодорхойлохын тулд шүүн тунгаалт хийх шаардлагатай байдаг.
49. Дахин үнэлгээ хийх давтамж нь уг дахин үнэлж буй үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс хамаардаг. Дахин үнэлсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь түүний дансны үнээс материаллагаар өөр болсон тохиолдолд дараагийн дахин үнэлгээг хийх шаардлагатай байдаг. Зарим үндсэн хөрөнгийн зүйлс нь үнэ цэнийн мэдэгдэхүйц ба эрс огцом өөрчлөлтөнд өртдөг тул жил бүр дахин үнэлгээ хийх шаардлагатай юм. Үнэ цэнэд нь ялимгүй бага өөрчлөлт ордог үндсэн хөрөнгийн зүйлсийн хувьд ингэж ойр ойрхон дахин үнэлгээ хийх шаардлагагүй байдаг. Харин ийм зүйлсийг зөвхөн гурав буюу таван жил тутам дахин үнэлэх шаардлагатай байж болно.
50. Үндсэн хөрөнгийн зүйлийг дахин үнэлсэн тохиолдолд тухайн хөрөнгийн дансны үнийг уг дахин үнэлсэн дүн болгож тохируулна. Тухайн хөрөнгийг дахин үнэлгээний өдөр доор дурдсан аргын аль нэгээр өөрчлөн бүртгэнэ:
- (а) Тухайн хөрөнгийн дансны үнийн хувьд хийсэн дахин үнэлгээтэй нийцэх тийм байдлаар нийт дансны үнийг тохируулна. Тухайлбал; зах зээлийн ажиглаж болох мэдээг лавлагаа болгосноор эсвэл дансны үнийн өөрчлөлттэй хувь тэнцүүлэх байдлаар (пропорциональ хамааралтайгаар) нийт дансны үнийг дахин тайлагнаж болно. Хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг харгалзсаны дараах уг хөрөнгийн дансны үнэ ба нийт дансны үнийн хоорондох зөрүүг тэнцүүлэхийн тулд тэрхүү дахин үнэлгээний өдрөөрх хуримтлагдсан элэгдлийг тохируулна; эсвэл
- (б) Хуримтлагдсан элэгдлийг тухайн хөрөнгийн нийт дансны үнээс хасна.
- Хуримтлагдсан элэгдэлд хийсэн тохируулгын дүн нь 54 ба 55-р параграфын дагуу тайлагнасан уг дансны үнийн өсөлт эсвэл бууралтын нэг хэсэг болно.
51. **Хэрэв үндсэн хөрөнгийн зүйлийг дахин үнэлэх бол тухайн хөрөнгийн харъяалагдаж буй үндсэн хөрөнгийн нийт ангийг дахин үнэлнэ.**

## ҮНДСЭН ХӨРӨНГӨ

- 51А. УСНББОУС 21 ба УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-ын дагуу хийгдэх хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз болон үнэ цэнийн бууралтын гарзын буцаалт нь тухайн хөрөнгө буюу хөрөнгүүдийн бүлгийн харъяалагдаж буй хөрөнгийн ангийг дахин үнэлэх шаардлагыг заавал бий болгохгүй юм.
52. Үндсэн хөрөнгийн анги гэдэг нь байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах байдлын хувьд ижил төсөөтэй шинж төрөл ба хэрэглээ бүхий хөрөнгүүдийн бүлэг юм. Ийм тусдаа ангиудын жишээг доор харуулав:
- (а) Газар;
  - (б) Үйл ажиллагаа явуулдаг барилга;
  - (в) Авто зам;
  - (г) Машин, тоног төхөөрөмж;
  - (д) Цахилгаан дамжуулах шугам сүлжээ;
  - (е) Усан онгоц;
  - (ж) Нисэх онгоц;
  - (и) Зэвсгийн систем;
  - (к) Тээврийн хэрэгсэл;
  - (л) Тавилга, эд хогшил;
  - (м) Оффисын тоног төхөөрөмж;
  - (н) Газрын тосны цооног;
  - (о) Эх ургамал.
53. Хөрөнгүүдээс сонголт хийж дахин үнэлэх, түүнчлэн өөр өөр хугацааны өртөг ба дахин үнэлсэн үнэ цэнийг хольж, санхүүгийн тайланд тусгахаас сэргийлэхийн тулд үндсэн хөрөнгийн нэг анги доторх зүйлсийг нэгэн зэрэг дахин үнэлнэ. Хэдий тийм боловч тухайн ангийн хөрөнгүүдийн дахин үнэлгээг богино хугацааны дотор хийж дуусгах ба уг үнэлгээ нь одоогийн цаг үетэй нийцсэн шинэлэг байлгах үүднээс хөрөнгийн ангийг хэсэгчилсэн сууриар үнэлж болно.
54. **Хэрэв дахин үнэлгээний үр дүнд хөрөнгүүдийн ангийн дансны үнэ нэмэгдвэл тэрхүү нэмэгдэлтийг дахин үнэлгээний нэмэгдэлд шууд кредитлэнэ. Харин өмнө нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн тухайн хөрөнгүүдийн ангийн дахин үнэлгээний бууралтыг буцааж буй хэмжээгээр тэрхүү нэмэгдэлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.**
55. **Хэрэв дахин үнэлгээний үр дүнд хөрөнгүүдийн ангийн дансны үнэ буурвал тэрхүү бууралтыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Харин тухайн нэг хөрөнгүүдийн ангитай холбоотой дахин үнэлгээний**

**нэмэгдэл дансанд тусгагдсан аливаа кредит үлдэгдлийн хэмжээгээр тэрхүү бууралтыг дахин үнэлгээний нэмэгдэлд шууд дебитлэнэ.**

56. **Үндсэн хөрөнгийн нэг анги доторх бие даасан хөрөнгүүдтэй холбоотой дахин үнэлгээний нэмэгдэл ба бууралтыг тэрхүү анги дотор өөр хооронд нь харилцан суутган цэвэр дүнг гаргах боловч өөр ангиудын хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл эсвэл бууралттай харилцан суутган хааж, цэвэр дүнг гаргах ёсгүй.**
57. Үндсэн хөрөнгөтэй холбоотойгоор цэвэр хөрөнгө/өмчид тусгагдсан дахин үнэлгээний бүх буюу зарим нэмэгдлийг тухайн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх (буюу данснаас хасах) үед хуримтлагдсан ашиг, алдагдалд шууд шилжүүлж болно. Энэ нь тухайн нэмэгдэл хамаарах үндсэн хөрөнгийн анги доторх хөрөнгүүдийг актлах буюу данснаас хасах үед тэрхүү дахин үнэлгээний нэмэгдлийг бүхэлд нь, эсвэл түүний зарим хэсгийг шилжүүлэх ажиллагаа байж болно. Гэвч уг хөрөнгийг тухайн байгууллага ашиглахын хирээр дахин үнэлгээний нэмэгдлийн зарим хэсгийг шилжүүлж болох юм. Ийм тохиолдолд уг шилжүүлсэн дахин үнэлгээний нэмэгдлийн дүн нь тухайн хөрөнгийн дахин үнэлсэн дансны үнээс тооцсон элэгдэл ба түүний анхны өртгөөс тооцсон элэгдлийн хоорондох зөрүү байдаг. Дахин үнэлгээний нэмэгдлээс хуримтлагдсан ашиг, алдагдалд хийгдэх шилжүүлэлтийг ашиг, алдагдлаар дамжуулан тусгахгүй.
58. Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний үр дүнд орлогын албан татварт үзүүлэх ямар нэг үр нөлөө хэрэв байгаа бол түүний заавар удирдамжийг орлогын татварын талаархи олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартуудаас үзэж болно.

### **Элэгдэл**

59. **Үндсэн хөрөнгийн тухайн зүйлийн нийт өртөгтэй харьцуулахад мэдэгдэхүйц өртөг бүхий хэсэг бүрийг тусад нь элэгдүүлнэ.**
60. Байгууллага нь тухайн үндсэн хөрөнгийн зүйлийн хувьд анх хүлээн зөвшөөрсөн дүнг түүний мэдэгдэхүйц хэсгүүдэд хуваарилах ба тэрхүү хэсэг тус бүрийг тусад нь элэгдүүлнэ. Жишээлбэл; авто замын системийн доторх замын хажуугийн явган зам, замын хучилт, замын хашлага, суваг, явган зам, гүүр, гэрлэн дохиог тусад нь элэгдүүлэхийг шаарддаг. Үүнтэй адилаар, онгоцыг өөрөө өмчилдөг эсвэл санхүүгийн түрээсээр түрээслэдэг эсэхээс үл хамаран нисэх онгоцны их бие ба түүний хөдөлгүүрийг тусад нь элэгдүүлэх нь тохиромжтой байж болох юм. Хэрэв байгууллага нь өөрөө түрээслүүлэгч байх тийм үйл ажиллагааны түрээсээр үндсэн хөрөнгийг түрээслэх үүднээс худалдан авсан бол зах зээлийн нөхцөлтэй харьцуулахад тааламжтай эсвэл тааламжгүй түрээсийн нөхцөлд хамаарах үндсэн хөрөнгийн зүйлсийн өртгийг тус тусад нь элэгдүүлэх нь тохиромжтой байж болно.

61. Үндсэн хөрөнгийн зүйлийн нэг мэдэгдэхүйц хэсэг нь үндсэн хөрөнгийн тухайн зүйлийн өөр нэг мэдэгдэхүйц хэсгийн ашиглалтын хугацаа ба элэгдлийн аргатай ижил тийм ашиглалтын хугацаа ба элэгдлийн аргатай байж болно. Элэгдлийн зардлыг тодорхойлохын тулд ийм хэсгүүдийг нэгтгэн бүлэглэж болох юм.
62. Байгууллага нь үндсэн хөрөнгийн зүйлийн зарим хэсгүүдийг тусад нь элэгдүүлдэг бол үлдсэн бусад хэсгүүдийг мөн тусад нь элэгдүүлнэ. Үлдсэн бусад хэсгүүд нь үндсэн хөрөнгийн тухайн зүйлийн хувьд тус тусдаа мэдэгдэхүйц бус дүнтэй байх тийм хэсгүүдээс бүрддэг. Хэрэв байгууллага нь эдгээр үлдсэн бусад хэсгүүдийн талаар өөр өөр хүлээлэлттэй байгаа бол тэдгээр хэсгүүдийн ашиглалт зарцуулалтын хэв загвар ба/буюу ашиглалтын хугацааг үнэн зөв төлөөлөн илэрхийлэх тийм арга маягаар уг үлдсэн бусад хэсгүүдийг элэгдүүлэхийн тулд ойролцоо тооцооллын арга зүйг ашиглах шаардлагатай байж болно.
63. Байгууллага нь тухайн үндсэн хөрөнгийн зүйлийн нийт өртөгтэй харьцуулахад мэдэгдэхүйц тийм өртөггүй хэсгүүдийг тусад нь элэгдүүлэхээр сонголт хийж болно.
64. **Тайлант үе бүрийн элэгдлийн зардлыг хэрэв өөр нэг хөрөнгийн дансны үнэд тусган оруулаагүй л бол ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.**
65. Тайлант үеийн элэгдлийн зардлыг ихэвчлэн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг. Гэвч хөрөнгөнд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь зарим үед өөр хөрөнгийг үйлдвэрлэн бий болгоход зарцуулагдан түүнд шингэдэг. Энэ тохиолдолд элэгдлийн зардал нь уг өөр хөрөнгийн өртгийн нэг хэсгийг бүрдүүлэх ба түүний дансны үнэд багтдаг. Жишээлбэл; үйлдвэрлэлийн барилга, тоног төхөөрөмжийн элэгдлийн зардлыг бараа материалын хувиргалтын зардалд оруулдаг (УСНББОУС 12-ыг үзнэ үү). Үүнтэй адилаар, хөгжүүлэлтийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг УСНББОУС 31, *Биет Бус Хөрөнгө*-ийн дагуу хүлээн зөвшөөрсөн биет бус хөрөнгийн өртөгт оруулж болох юм.

*Элэгдүүлэх дүн ба элэгдлийн хугацаа*

66. **Хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид системчилсэн сууриар хуваарилна.**
67. **Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-ны дагуу нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт байдлаар тайлагнана.**
68. Хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээс илүү байлаа ч гэсэн уг хөрөнгийн үлдэх өртөг нь түүний дансны үнээс хэтрээгүй байх тийм

## ҮНДСЭН ХӨРӨНГӨ

нөхцөлд элэгдлийг хүлээн зөвшөөрнө. Хөрөнгийн засвар, үйлчилгээ нь түүнийг элэгдүүлэх шаардлагыг үгүйсгэхгүй юм. Харин эсрэгээр, төсвийн хязгаарлалтын улмаас зарим хөрөнгөнд засвар үйлчилгээ муу хийсэн эсвэл засвар үйлчилгээг тодорхой бус хугацаагаар хойшлуулсан байж болно. Хөрөнгийн удирдлагын бодлого нь хөрөнгийн элэгдэл хуучралтыг нэмэгдүүлдэг тохиолдолд түүний ашиглалтын хугацааг дахин хянан үнэлж, зохих ёсоор залруулах хэрэгтэй.

69. Хөрөнгийн үлдэх өртгийг хассаны дараа түүний элэгдүүлэх дүнг тодорхойлдог. Практикт, хөрөнгийн үлдэх өртөг нь ихэвчлэн маш бага дүнтэй, иймээс элэгдүүлэх дүнгийн тооцоололд материаллаг бус нөлөөтэй байдаг.
70. Хөрөнгийн үлдэх өртөг нь тухайн хөрөнгийн дансны үнэтэй тэнцүү эсвэл түүнээс их болон өсөж болох юм. Хэрэв ийм тохиолдол гарвал, үлдэх өртөг дараа нь буурч, тухайн хөрөнгийн дансны үнээс бага болох хүртэл, түүнчлэн ингэж бага болохгүй байх үед уг хөрөнгийн элэгдлийн зардал нь тэг байна.
71. Үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болсон үеэс өөрөөр хэлбэл, удирдлагын төлөвлөсөн арга маягаар ажиллуулах боломжтой болгоход шаардлагатай тийм байршил болон нөхцөл байдалд уг хөрөнгийг авчирсан үеэс эхлэн элэгдүүлнэ. Хөрөнгийг үл хүлээн зөвшөөрсөн үед хөрөнгийн элэгдлийг зогсооно. Иймээс хөрөнгийг бүрэн элэгдүүлээгүй л бол түүнийг ашиглаагүй сул зогссон эсвэл идэвхитэй ашиглалтаас хассан ба данснаас хасах зорилгоор эзэмшиж байгаа тохиолдолд элэгдлийг зогсоохгүй. Харин хөрөнгийн ашиглалтанд үндэслэсэн элэгдлийн аргыг хэрэглэж байгаа тохиолдолд ямар нэг үйлдвэрлэл явуулаагүй бол элэгдлийн зардал нь тэг байж болно.
72. Байгууллага нь үндсэн хөрөнгөнд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг үндсэндээ тухайн хөрөнгийн ашиглалтаар дамжуулан хэрэглэж зарцуулдаг. Гэвч хөрөнгийг ашиглаагүй сул зогсолтын үед технологийн буюу арилжааны хоцрогдол, хэвийн элэгдэл хуучралт гэх мэт бусад хүчин зүйлсийн улмаас тухайн хөрөнгөөс олж болох эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи байнга багасаж байдаг. Иймээс хөрөнгийн ашиглалтын хугацааг тодорхойлохдоо дараах бүх хүчин зүйлсийг харгалзан үзэх хэрэгтэй:
- (а) Хөрөнгийн хүлээгдэж буй ашиглалт. Тухайн хөрөнгийн хүлээгдэж буй хүчин чадал буюу биет гарцыг лавлагаа болгосноор ашиглалтыг үнэлнэ.
  - (б) Хүлээгдэж буй биет элэгдэл хуучралт, энэ нь тухайн хөрөнгийг ашиглах ээлжийн тоо, засвар үйлчилгээний хөтөлбөр, хөрөнгийг ашиглаагүй сул зогсолтын үеийн хадгалалт хамгаалалт гэх мэт үйл ажиллагааны хүчин зүйлсээс хамаардаг.
  - (в) Технологийн буюу арилжааны хоцрогдол, энэ нь үйлдвэрлэлийн өөрчлөлт буюу сайжруулалт, эсвэл тухайн хөрөнгийн гарц болох



## ҮНДСЭН ХӨРӨНГӨ

бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн эрэлтийн өөрчлөлтийн улмаас үүсдэг. Хөрөнгийг ашиглаж, үйлдвэрлэсэн зүйлсийн борлуулалтын үнийн ирээдүйн хүлээгдэж буй бууралт нь тухайн хөрөнгийн технологийн буюу арилжааны хоцрогдлын хүлээлтийг харуулах ба эргээд энэ нь уг хөрөнгөнд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн бууралтыг илэрхийлж болох юм.

(г) Холбогдох түрээсийн дуусах хугацаа гэх мэт уг хөрөнгийн ашиглалтанд тавигдах хууль эрх зүйн буюу адилтгах хязгаарлалтууд.

73. Тухайн байгууллагын хувьд уг хөрөнгийн хүлээгдэж буй ашиглалтын нөхцлөөр хөрөнгийн ашиглалтын хугацааг тодорхойлно. Байгууллагын хөрөнгийн удирдлагын бодлогын дагуу, тогтоосон хугацааны дараа эсвэл уг хөрөнгөнд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн тодорхой хэсгийг хэрэглэн зарцуулсаны дараа тухайн хөрөнгийг данснаас хасдаг байж болох юм. Иймээс хөрөнгийн ашиглалтын хугацаа нь түүний эдийн засгийн үр ашигт хугацаанаас богино байж болно. Хөрөнгийн ашиглалтын хугацааны тооцоолол нь ижил төсөөтэй хөрөнгүүдийн талаархи уг байгууллагын туршлагад үндэслэсэн шүүн тунгаалтын асуудал юм.
74. Газар ба барилгыг хамтад нь худалдан авсан байлаа ч гэсэн тэдгээр нь тусдаа салгаж болох хөрөнгүүд бөгөөд тус тусад нь бүртгэж, тайлагнадаг. Хайрга бэлтгэх (карьер) болон хог булах зориулалттай газар гэх мэт зарим гажих нөхцлөөс бусад тохиолдолд газар нь хязгааргүй ашиглалтын хугацаатай тул элэгдэл тооцдоггүй. Барилга нь хязгаарлагдмал ашиглалтын хугацаатай, иймээс элэгдэх хөрөнгө юм. Барилга барьсан газрын үнэ цэнийн өсөлт нь тухайн барилгын элэгдүүлэх дүнг тодорхойлоход нөлөө үзүүлэхгүй.
75. Хэрэв газрын өртөг нь хуучин барилгыг буулгаж нураах, холдуулж зайлуулах ба түүний байрлаж байсан талбайг цэвэрлэж, хэвийн байдалд оруулах өртөг зардлыг багтаасан бол уг газар гэсэн хөрөнгийн тэрхүү хэсгийг тухайн өртөг зардлыг гаргаснаар үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи олж авах хугацааны туршид элэгдүүлнэ. Зарим тохиолдолд газар нь өөрөө хязгаарлагдмал ашиглалтын хугацаатай байж болох бөгөөд уг газраас олж болох үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг тусгах тийм байдлаар түүнийг элэгдүүлнэ.

### *Элэгдлийн арга*

76. **Элэгдлийн арга нь тухайн байгууллага уг хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг ашиглан зарцуулахаар хүлээгдэж буй хэв загварыг тусгана.**
77. **Хөрөнгийн хувьд хэрэглэх элэгдлийн аргыг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба тухайн хөрөнгөнд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг**

**ашиглах зарцуулахаар хүлээгдэж буй хэв загварт мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан бол тэрхүү өөрчлөгдсөн хэв загварыг тусгахын тулд элэгдлийн аргыг өөрчлөх хэрэгтэй. Ийм өөрчлөлтийг УСНББОУС 3-ын дагуу нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт байдлаар тайлагнана.**

78. Хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид системтэйгээр хуваарилахын тулд элэгдлийн янз бүрийн аргуудыг ашиглаж болно. Эдгээр аргад шулуун шугамын арга, үлдэгдлийг бууруулах арга, бүтээгдэхүүний нэгжийн арга хамаарна. Хэрэв хөрөнгийн үлдэх өртөг өөрчлөгдөөгүй бол шулуун шугамын элэгдэл нь хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид зардлыг тогтмол дүнгээр тооцоолдог. Үлдэгдлийг бууруулах аргаар тооцсон элэгдлийн зардал нь ашиглалтын хугацааны туршид жилээс жилд буурдаг. Бүтээгдэхүүний нэгжийн арга нь хөрөнгийн хүлээгдэж буй ашиглалт буюу гарцад үндэслэн элэгдлийн зардлыг тооцоолдог. Байгууллага нь тухайн хөрөнгөнд агуулагдаж байгаа ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг ашиглан зарцуулах хүлээгдэж буй хэв загварыг хамгийн ойролцоо тусган илэрхийлэх тийм аргыг сонгодог. Тэрхүү ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг зарцуулахаар хүлээгдэж буй хэв загвар өөрчлөгдөхгүй л бол тухайн аргаа нэг тайлант үеэс нөгөө тайлант үед тууштай мөрдөнө.
- 78А. Тухайн хөрөнгийг ашиглан явуулах үйл ажиллагааны үр дүнд бий болох орлогод үндэслэсэн элэгдлийн арга нь тохиромжтой биш байдаг. Хөрөнгийг ашиглан явуулах үйл ажиллагааны үр дүнд бий болсон орлого нь ерөнхийдөө уг хөрөнгийн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн зарцуулалтаас өөр бусад хүчин зүйлсийн нөлөөг тусган илэрхийлдэг. Тухайлбал; бусад орц ба боловсруулалтууд, борлуулалтын үйл ажиллагаа, борлуулалтын тоо хэмжээний болон үнийн өөрчлөлт зэрэг нь орлогод нөлөө үзүүлдэг. Уг орлогын үнийн бүрэлдэхүүн хэсэгт тухайн хөрөнгийг ашиглан зарцуулж буй арга замаас хамааралгүй инфляци гэх мэт хүчин зүйлс нөлөөлдөг.

### **Үнэ цэнийн бууралт**

79. Үндсэн хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэхийг тодорхойлохдоо, байгууллага нь УСНББОУС 21 эсвэл УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-ыг мөрдөнө. Байгууллага нь хөрөнгийн дансны үнийг хэрхэн хянаж үзэх, түүний нөхөгдөх үйлчилгээний дүн буюу нөхөгдөх дүнг хэрхэн тодорхойлох, үнэ цэнийн бууралтын гарзыг хэзээ хүлээн зөвшөөрөх буюу уг хүлээн зөвшөөрөлтийг буцаах эсэхийг энэ Стандартад тайлбарласан байдаг.

### **Үнэ цэнийн бууралтын нөхөн төлбөр**

80. **Үнэ цэнэ буурсан, гарз хүлээсэн эсвэл шилжүүлэн өгсөн үндсэн хөрөнгийн зүйлсийн хувьд гуравдагч талаас авахаар авлага үүссэн үед нөхөн төлбөрийг ашиг, алдагдалд тусгана.**

81. Үндсэн хөрөнгийн зүйлийн үнэ цэнийн бууралт буюу гарз, гуравдагч талд гаргасан холбогдох нэхэмжлэл буюу гуравдагч талаас авах нөхөн төлбөрийн төлөлт, орлуулах хөрөнгийн дараагийн тайлант үеийн аливаа худалдан авалт буюу барьж байгуулалт нь эдийн засгийн тусдаа үйл явдлууд бөгөөд дараах байдлаар тусад нь бүртгэж, тайлагнана:
- (а) Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг УСНББОУС 21 эсвэл УСНББОУС 26-гийн аль тохиромжтой стандартын дагуу хүлээн зөвшөөрнө;
  - (б) Актлалт буюу данснаас хасалтаар үндсэн хөрөнгийн зүйлийн үл хүлээн зөвшөөрөлтийг энэ Стандартын дагуу тодорхойлно;
  - (в) Үнэ цэнэ буурсан, гарз хүлээсэн эсвэл шилжүүлэн өгсөн үндсэн хөрөнгийн зүйлсийн хувьд гуравдагч талаас авахаар авлага үүссэн үед нөхөн төлбөрийг ашиг, алдагдалд тусгана;
  - (г) Орлуулалт байдлаар дахин сэргээсэн, худалдан авсан буюу барьж байгуулсан үндсэн хөрөнгийн зүйлсийн ертгийг энэ Стандартын дагуу тодорхойлно.

### **Үл хүлээн зөвшөөрөлт**

82. **Үндсэн хөрөнгийн зүйлийн дансны үнийг дараах тохиолдолд үл хүлээн зөвшөөрнө:**
- (а) **Данснаас хассан; эсвэл**
  - (б) **Хөрөнгийн ашиглалт эсвэл данснаас хасалтаас ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи хүлээгдэхээргүй болсон.**
83. **Үндсэн хөрөнгийн зүйлийн үл хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн олз буюу гарзыг тухайн зүйлийг үл хүлээн зөвшөөрсөн үед (УСНББОУС 13 нь борлуулах ба буцаан түрээслэх ажил гүйлгээний хувьд өөрөөр зааснаас бусад тохиолдолд) ашиг, алдагдалд тусган оруулна.**
- 83А. Харин бусдад түрээслэх зорилгоор эзэмшиж байсан үндсэн хөрөнгөө өөрийн хэвийн үйл ажиллагааны явцад байнга борлуулдаг байгууллага нь үндсэн хөрөнгөө түрээслэхээ больж, борлуулах зорилгоор эзэмших болсон тохиолдолд тэрхүү үндсэн хөрөнгийг түүний дансны үнээр бараа материал дансанд шилжүүлнэ. Ийм хөрөнгийн борлуулалтаас олсон орлогыг УСНББОУС 9, *Арилжааны Ажил Гүйлгээний Орлого*-ын дагуу орлого гэж хүлээн зөвшөөрнө.
84. Үндсэн хөрөнгийн данснаас хасалтыг янз бүрийн арга замаар (жишээлбэл; борлуулах, санхүүгийн түрээсээр өгөх, хандивлах) гүйцэтгэж болох юм. Хөрөнгийн данснаас хасалтын өдрийг тодорхойлохдоо, байгууллага нь бараа борлуулалтаас үүссэн орлогын хүлээн зөвшөөрөлтийн хувьд УСНББОУС 9-д заасан шалгуурыг хэрэглэнэ. Борлуулах ба буцаан түрээслэх ажил гүйлгээгээр хийгдсэн данснаас хасалтын хувьд УСНББОУС 13-ыг мөрдөнө.

85. Хэрэв 14-р параграфт заасан хүлээн зөвшөөрөлтийн зарчмын дагуу, байгууллага нь тухайн үндсэн хөрөнгийн зүйлийн тодорхой хэсгийн хувьд орлуулан нэмэгдэж буй зүйлсийн өртгийг уг үндсэн хөрөнгийн дансны үнэд оруулан хүлээн зөвшөөрдөг бол тэрхүү орлуулагдан хасагдаж буй хэсгийг тусдаа элэгдүүлдэг эсэхээс үл хамааран түүний дансны үнийг үл хүлээн зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь орлуулагдан хасагдаж буй хэсгийн дансны үнийг тодорхойлох практик боломжгүй байвал тэрхүү орлуулагдан хасагдаж буй хэсгийг худалдан авах буюу барьж байгуулах тухайн хугацааны өртгийн үзүүлэлт гэдэг утгаар уг орлуулан нэмэгдэж буй өртгийг ашиглаж болох юм.
86. **Үндсэн хөрөнгийн зүйлийн үл хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн олз буюу гарзыг хэрэв байгаа бол данснаас хасалтын цэвэр орлого ба тухайн хөрөнгийн дансны үнэ хоорондох зөрүүгээр тодорхойлно.**
87. Үндсэн хөрөнгийн зүйлийн данснаас хасалтаар авах төлбөрийг эхлээд түүний бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрнө. Хэрэв тухайн зүйлийн төлбөрийг хойшлуулдаг бол уг хүлээн авах төлбөрийг эхлээд түүний мөнгөн үнэтэй адилтгах дүнгээр хүлээн зөвшөөрнө. Төлбөрийн нэрлэсэн дүн ба мөнгөн үнэтэй адилтгах дүн хоорондох зөрүүг уг авлагын үр ашигт өгөөжийг тусгаснаар УСНББОУС 9-ийн дагуу хүүний орлого гэж хүлээн зөвшөөрнө.

## Тодруулга

88. **Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн үндсэн хөрөнгийн анги тус бүрийн хувьд дараах зүйлсийг санхүүгийн тайланд тодруулна:**
- (а) **Нийт дансны үнийг тодорхойлоход ашигласан хэмжилтийн сууриуд;**
  - (б) **Ашигласан элэгдлийн арга;**
  - (в) **Ашиглалтын хугацаа буюу ашигласан элэгдлийн хувь хэмжээ;**
  - (г) **Тайлант үеийн эхэн ба эцэс дэх нийт дансны үнэ ба хуримтлагдсан элэгдэл (хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзтай нэгтгэн нийлүүлсэн); ба**
  - (д) **Доорх зүйлсийг харуулсан, тайлант үеийн эхэн ба эцэс дэх дансны үнийн тохируулга:**
    - (i) **Нэмэгдэлт;**
    - (ii) **Данснаас хасалт;**
    - (iii) **Улсын секторын нэгдлээрх худалдан авалт;**
    - (iv) **44, 54, 55-р параграфын дагуу дахин үнэлгээний үр дүнд, түүнчлэн УСНББОУС 21 эсвэл УСНББОУС 26-гийн аль тохиромжтой стандартын дагуу цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн эсвэл түүнээс буцаасан үнэ цэнийн бууралтын гарзын (хэрэв байгаа бол) үр дүнд нэмэгдсэн буюу буурсан дүн;**

- (v) **УСНББОУС 21 эсвэл УСНББОУС 26-гийн аль тохиромжтой стандартын дагуу ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарз;**
  - (vi) **УСНББОУС 21 эсвэл УСНББОУС 26-гийн аль тохиромжтой стандартын дагуу ашиг, алдагдалд буцаан тусгасан үнэ цэнийн бууралтын гарз;**
  - (vii) **Элэгдэл;**
  - (viii) **Санхүүгийн тайланг толилуулгын валютаас өөр валютаар хөрвүүлснээс, үүн дотроо гадаад үйл ажиллагааг тухайн тайлагнагч байгууллагын толилуулгын валютад хөрвүүлснээс үүссэн ханшийн цэвэр зөрүү; ба**
  - (ix) **Бусад өөрчлөлтүүд.**
89. **Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн үндсэн хөрөнгийн анги тус бүрийн хувьд мөн дараах зүйлсийг санхүүгийн тайланд тодруулна:**
- (a) **Үндсэн хөрөнгийн эрхийн хязгаарлалт ба түүний дүн, түүнчлэн өр төлбөрийн баталгаа болгон барьцаалсан үндсэн хөрөнгө;**
  - (б) **Барьж байгуулах явцад тухайн үндсэн хөрөнгийн дансны үнэд хүлээн зөвшөөрсөн зарлагын дүн;**
  - (в) **Үндсэн хөрөнгийг худалдан авах талаархи гэрээний хариуцлагын дүн;**
  - (г) **Хэрэв санхүүгийн тайланд тусдаа толилуулаагүй бол үнэ цэнэ буурсан, гарз хүлээсэн эсвэл шилжүүлэн өгсөн үндсэн хөрөнгийн зүйлсийн хувьд гуравдагч талаас авах бөгөөд ашиг, алдагдалд тусган оруулсан нөхөн төлбөрийн дүн.**
90. Элэгдлийн аргын сонголт ба хөрөнгийн ашиглалтын хугацааны тооцоолол нь шүүн тунгаалт хийх асуудал юм. Иймээс мөрдөн хэрэглэж буй арга, тооцоолсон ашиглалтын хугацаа буюу элэгдлийн хувь хэмжээний талаархи тодруулга нь удирдлагын сонгосон бодлогыг хянаж үзэх ба бусад байгууллагуудтай зэрэгцүүлэх боломжийг санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгох тийм мэдээллээр хэрэглэгчдийг хангадаг. Үүнтэй адил шалтгаанаар, дараах зүйлсийг тодруулах шаардлагатай байдаг:
- (a) **Элэгдэл, түүнийг тайлант үеийн туршид ашиг, алдагдалд эсвэл өөр бусад хөрөнгийн өртгийн нэг хэсэг болгон хүлээн зөвшөөрсөн эсэх; ба**
  - (б) **Тухайн тайлант үеийн эцэс дэх хуримтлагдсан элэгдэл.**
91. Байгууллага нь тухайн тайлант үед үр нөлөөтэй буюу дараагийн тайлант үеүдэд үр нөлөөтэй байхаар хүлээгдэж буй нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтийн шинж төрөл ба үр нөлөөг УСНББОУС 3-ын дагуу тодруулна. Үндсэн хөрөнгийн хувьд дараах зүйлсийн талаархи тооцооллын өөрчлөлтийн улмаас ийм тодруулгыг хийж болох юм:
- (a) **Үлдэх өртөг;**

## ҮНДСЭН ХӨРӨНГӨ

- (б) Үндсэн хөрөнгийн зүйлийг буулгаж нураах, холдуулж зайлуулах буюу цэвэрлэж, хэвийн байдалд оруулах тооцоолсон өртөг зардал;
- (в) Ашиглалтын хугацаа; ба
- (г) Элэгдлийн аргууд.

92. **Хэрэв үндсэн хөрөнгийн ангийг дахин үнэлсэн дүнгээр илэрхийлсэн бол дараах зүйлсийн тодруулгыг хийнэ:**

- (а) **Дахин үнэлгээний хүчин төгөлдөр болох өдөр;**
- (б) **Хараат бус үнэлгээчинг оролцуулсан эсэх;**
- (в) **Хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцоолохдоо хэрэглэсэн аргууд болон мэдэгдэхүйц таамаглалууд;**
- (г) **Хөрөнгийн бодит үнэ цэнийг идэвхитэй зах зээл дэх эсвэл харилцан хамааралгүй нөхцлөөр сүүлийн үед хийгдсэн зах зээлийн ажил гүйлгээгээр ажиглаж болох үнийг шууд лавлагаа болгосноор тодорхойлсон буюу үнэлгээний бусад арга зүйг ашиглан тооцоолсон хэмжээ;**
- (д) **Дахин үнэлгээний нэмэгдэл, үүнд тайлант үед гарсан өөрчлөлт ба хувьцаа эзэмшигчдэд буюу өмчийн бусад эзэмшигчдэд хуваарилах үлдэгдэлд тавигдах аливаа хязгаарлалтыг заан илэрхийлэх.**
- (е) **Тухайн ангийн доторх үндсэн хөрөнгийн бие даасан зүйлсэд хамаарах дахин үнэлгээний бүх нэмэгдлийн нийлбэр дүн; ба**
- (ж) **Тухайн ангийн доторх үндсэн хөрөнгийн бие даасан зүйлсэд хамаарах дахин үнэлгээний бүх бууралтын нийлбэр дүн.**

93. Энэ Стандартын 88(д)(iv)-(vi) параграфтаар шаардсан мэдээллээс гадна байгууллага нь үнэ цэнэ буурсан үндсэн хөрөнгийн талаархи мэдээллийг УСНББОУС 21 ба УСНББОУС 27-гийн дагуу тодруулна.

94. Санхүүгийн тайлангийн хэрэглэгчид нь мөн дараах мэдээллийг тэдэнд ач холбогдолтой гэж үзэж болох юм:

- (а) Түр сул зогсож байгаа үндсэн хөрөнгийн дансны үнэ;
- (б) Бүрэн элэгдсэн боловч одоо ч ашиглагдсаар байгаа аливаа үндсэн хөрөнгийн нийт дансны үнэ;
- (в) Идэвхитэй ашиглалтаас хассан болон данснаас хасах зорилгоор эзэмшиж буй үндсэн хөрөнгийн дансны үнэ; ба
- (г) Өртгийн загварыг ашиглаж байгаа тохиолдолд дансны үнээс материаллаг зөрүүтэй байгаа үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ.

Иймээс дээрх дүнгүүдийг байгууллагууд нь тодруулахыг дэмжинэ.

## Шилжилтийн нөхцөл

95. [Хассан]
96. [Хассан]
97. [Хассан]
98. [Хассан]
99. [Хассан]
100. [Хассан]
101. [Хассан]
102. [Хассан]
103. [Хассан]
104. [Хассан]
105. **УСНББОУС 17 (2001)-г өмнө нь мөрдөж байсан байгууллагуудын хувьд хөрөнгийн солилцооны ажил гүйлгээгээр олж эзэмшсэн үндсэн хөрөнгийн анхны хэмжилтийн талаархи 38-40-р параграфын шаардлагуудыг зөвхөн ирээдүйн ажил гүйлгээнүүдэд гүйцээх горимоор мөрдөнө.**
106. УСНББОУС 17 (2001)-гийн шилжилтийн нөхцлүүд нь бүх үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрөх ба холбогдох хэмжилт, тодруулгыг хийхэд зориулан уг Стандартыг анх мөрдсөн өдрөөс эхлэн тав хүртэлх жилийн хугацааг байгууллагуудад олгодог. Өмнө нь УСНББОУС 17 (2001)-г мөрдөж байсан байгууллагууд нь УСНББОУС 17 (2001)-г анх мөрдсөн өдрөөс эхлэн энэхүү таван жилийн шилжилтийн хугацааны давуу талыг үргэлжлүүлэн ашиглаж болох юм. Эдгээр байгууллагууд нь 104-р параграфар шаардсан тодруулгуудыг мөн үргэлжлүүлэн хийнэ.
- 106А. 2015 оны 01 дүгээр сард гаргасан, *УСНББОУС 2014-ийн Сайжруулалтууд*-аар 50-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг анх мөрдөж эхэлсэн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант жилүүд болон үүний яг өмнөх тайлант жилд хүлээн зөвшөөрсөн бүх дахин үнэлгээний хувьд эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг даган мөрдөнө.

## Хүчин төгөлдөр болох хугацаа

107. **Байгууллага нь энэхүү Стандартыг 2008 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2008 оны 01**

дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.

- 107А. 2010 оны 01 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Сайжруулалтууд*-аар 83А параграфыг шинээр нэмж, 84-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2011 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2011 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 2, *Мөнгөн Гүйлгээний Тайлан*-г даган мөрдөнө.
- 107Б. 2010 оны 01 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Сайжруулалтууд*-аар 8-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2011 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд гүйцээх горимоор мөрдөнө. Хэрэв байгууллага нь УСНББОУС 16-гийн 12, 13, 29, 40, 57, 59, 62, 62А, 62Б, 63, 66, 101А параграфуудын нэмэлт өөрчлөлтүүдийг энд дурдсан хугацаанаас өмнө мөрдсөн бол энэ нэмэлт өөрчлөлтийг мөн дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2011 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 107В. 2011 оны 10 дугаар сард гаргасан УСНББОУС 32, *Үйлчилгээний Концессын Хэлцэл: Эрх бүхий этгээд*-ээр 5 ба 7-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2014 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2014 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 32, УСНББОУС 5-ын 6, 42А параграфын нэмэлт өөрчлөлт, УСНББОУС 13-ын 25-27, 85Б параграфуудын нэмэлт өөрчлөлт, УСНББОУС 29-ийн 2, 125А параграфуудын нэмэлт өөрчлөлт, УСНББОУС 31-ийн 6, 132А параграфын нэмэлт өөрчлөлтийг тус тус даган мөрдөнө.
- 107Г. 2011 оны 10 дугаар сард гаргасан *УСНББОУС 2011-ийн Сайжруулалтууд*-аар 79, 81, 83, 88, 93-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2013 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2013 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.



- 107Д. 2015 оны 01 дүгээр сард гаргасан *УСНББОУС 2014-ийн Сайжруулалтууд*-аар 17, 50, 72-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулж, 78А, 106А параграфуудыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2015 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2015 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 107Е. 2015 оны 01 дүгээр сард гаргасан *УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-ийн үр дүнд 95, 96, 97, 98, 99, 100, 101, 102, 103, 104, 108-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед *УСНББОУС 33*-ыг мөрдсөн бол эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.
- 107Ж. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд*-аар 5, 20, 52-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 107И. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд*-аар 6, 13, 52-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулж, 36А параграфыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ. 107Н параграфт тусгайлан зааснаас бусад тохиолдолд байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг *УСНББОУС 3, Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-ны дагуу буцаах горимоор мөрдөнө.
- 107К. *УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд*-ын IV хэсгийн үр дүнд *УСНББОУС 17* ба *УСНББОУС 27*-д хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг анх удаа мөрдөж буй тайлант үеийн хувьд байгууллага нь *УСНББОУС 3*-ын 33(е) параграфтаар шаардсан тоон шинжтэй

мэдээллийг тухайн тайлант үед тодруулах шаардлагагүй юм. Гэвч байгууллага нь толилуулсан өмнөх тайлант үе тус бүрийн хувьд УСНББОУС 3-ын 33(е) параграфтаар шаардсан тоон шинжтэй мэдээллийг толилуулна.

- 107Л. *УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд*-ын IV хэсгийн үр дүнд УСНББОУС 17 ба УСНББОУС 27-д хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг анх удаа мөрдөж байгаа тайлант үеийн санхүүгийн тайландаа тусгасан хамгийн эхний өмнөх тайлант үеийн эхний байдлаар эх ургамлыг түүний бодит үнэ цэнээр хэмжих ба уг бодит үнэ цэнийг тухайн өдрөөрх төсөөлөн тооцсон үнэ болгон ашиглах сонголт хийж болно. Уг өмнөх дансны үнэ ба бодит үнэ цэнийн хоорондох аливаа зөрүүг тухайн толилуулж буй хамгийн эхний тайлант үеийн эхний байдлаарх хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдэлд хүлээн зөвшөөрнө.
- 107М. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 3, 4-р параграфуудыг хассан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 107Н. *Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт* (УСНББОУС 21 ба 26-гийн нэмэлт өөрчлөлтүүд)-аар 51А параграфыг шинээр нэмсэн. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 107О. 2016 оны 7 дугаар сард гаргасан УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийн үр дүнд 31-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 39-ийг мөрдөнө.
- 107П. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийн үр дүнд 60, 88-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01

**дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.**

108. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

### **УСНББОУС 17 (2001)-гоос татгалзах**

109. Энэ Стандарт нь 2001 онд гаргасан УСНББОУС 17, *Үндсэн Хөрөнгө*-ийг орлоно.

**Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт**

[Хассан]

## Дүгнэлтийн Үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 17-г дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

**НББОУСЗ-ийн Ерөнхий Сайжруулалтын Төсөл 2003-ын үр дүнд УСНББОУС 17-г хянан засварласан.**

*Оршил*

ДҮ1. УСНББОУСЗ-ийн СТОУС-тай нийцүүлэх хөтөлбөр нь УСНББОУСЗ-ийн ажлын хөтөлбөрийн чухал элемент юм. УСНББОУСЗ-ийн бодлого нь улсын секторын байгууллагуудад тохиромжтой тохиолдолд НББОУСЗ-өөс гаргасан СТОУС-тай аккруэл суурьт УСНББОУС-ыг нийцүүлэх явдал юм.

ДҮ2. Улсын секторын хувьд гажих тусгай учир шалтгаан байхаас бусад тохиолдолд СТОУС-тай нийцүүлсэн, аккруэл суурьт УСНББОУС нь СТОУС-ын шаардлага, бүтэц, текстийг тэр хэвээр хадгална. СТОУС-ын шаардлага буюу нэр томъёо нь улсын секторт тохиромжгүй эсвэл улсын секторын хувьд зарим тодорхой шаардлагуудыг үлгэрчлэн харуулахын тулд нэмэлт тайлбар буюу жишээ оруулах шаардлагатай тохиолдолд адилтгах СТОУС-аас гаждаг. УСНББОУС-ууд ба тэдгээртэй адилтгах СТОУС-уудын хоорондох ялгаатай талуудыг УСНББОУС нэг бүрд тусган оруулсан *СТОУС-тай Харьцуулалт*-д тодорхойлсон.

ДҮ3. 2002 оны 5 дугаар сард өөрийн Ерөнхий Сайжруулалтын Төслийн нэг хэсэг болгон НББОУСЗ нь 13-н НББОУС<sup>2</sup>-д оруулахаар санал болгосон нэмэлт өөрчлөлтийн саналын төслийг гаргасан. НББОУСЗ-ийн Ерөнхий Сайжруулалтын Төслийн зорилго нь “Стандартуудын хүрээн дэх сонголтод олон хувилбарууд, илүүдэл зүйлс, зөрчилтэй заалтуудыг арилгах буюу бууруулах, нийцүүлэлтийн зарим асуудлуудыг шийдэх ба бусад сайжруулалтыг хийх”-д оршино. НББОУС-ын эцсийн хувилбарыг 2003 оны 12 дугаар сард гаргасан.

ДҮ4. 2001 оны 12 дугаар сард гаргасан УСНББОУС 17 нь НББОУС 16, *Үндсэн Хөрөнгө* (1998 онд хянан засварласан)-д үндэслэсэн. НББОУС 16-г 2003 оны 12 дугаар сард дахин гаргасан. УСНББОУСЗ-ийн өмнөх байгууллага болох Улсын Секторын Хороо (УСХ)<sup>3</sup> нь 2003 оны 12 дугаар сард гаргасан, сайжруулсан НББОУС-тай тохиромжтой хэмжээгээр УСНББОУС-ыг нийцүүлэхийн тулд УСНББОУС-ыг сайжруулах төслийг 2003 оны эцсээр хэрэгжүүлж эхэлсэн.

---

<sup>2</sup> НББОУСЗ-ийн өмнөх байгууллага болох НББОУСХ-ноос НББОУС-ыг гаргасан. НББОУСЗ-өөс гаргасан стандартуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) гэж нэрлэдэг. СТОУС-ыг НББОУСЗ нь СТОУС, НББОУС, Стандартын Тайлбаруудаас бүрдэнэ гэж тодорхойлсон. Зарим тохиолдолд НББОУСЗ нь НББОУС-ыг сольж орлуулахгүй, харин нэмэлт өөрчлөлт оруулдаг бөгөөд ингэснээр хуучин НББОУС-ын дугаарлалт хэвээр үлддэг.

<sup>3</sup> ДНБХ-ны Зөвлөл нь УСХ-г стандарт тогтоох бие даасан зөвлөл болгохын тулд түүний бүрэн эрхийг 2004 оны 11 дүгээр сард өөрчилснөөр УСХ нь УСНББОУСЗ болсон.

- ДҮ5. УСНББОУСЗ нь уг сайжруулсан НББОУС 16-г нягталж шалгаад ингэж хянан засварлах болсон НББОУСЗ-ийн учир шалтгаан болон хийсэн нэмэлт өөрчлөлттэй ерөнхийдөө санал нэгдсэн. (НББОУСЗ-ийн Дүгнэлтийн Үндэслэлийг энд дахин нийтлээгүй болно. НББОУСЗ-ийн *Цогц Захиалгын Үйлчилгээ*-гээр захиалагч нар нь [www.iasb.org](http://www.iasb.org) хаягаар орж, НББОУСЗ-ийн вэб сайтаас Дүгнэлтийн Үндэслэлийг үзэж болно). УСНББОУС нь адилтгах НББОУС-аас гажих тохиолдолд улсын секторын хувьд гажих тусгай учир шалтгааныг Дүгнэлтийн Үндэслэлд тайлбарладаг.
- ДҮ6. НББОУС 16, *Үндсэн Хөрөнгө* нь нөхөгдөх дүнг “хөрөнгийн борлуулалтын цэвэр үнэ ба түүний ашиглалтын үнэ цэнийн аль өндөр нь” гэж тодорхойлдог. УСНББОУС 17 нь нөхөгдөх дүнг “мөнгө бий болгогч хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ ба түүний ашиглалтын үнэ цэнийн аль өндөр нь” гэж тодорхойлдог. УСНББОУС 17 дахь тодорхойлолт нь УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт* дахь тодорхойлолттой ижил боловч НББОУС 16-гийн тодорхойлолтоос өөр юм. УСНББОУС 17 дахь тодорхойлолт нь дараах учир шалтгааны улмаас тохиромжтой гэж УСНББОУСЗ үздэг:
- (а) УСНББОУС 17 нь нөхөгдөх үйлчилгээний дүнг УСНББОУС 21, *Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-ын дагуу тодорхойлохыг байгууллагаас шаарддаг;
  - (б) УСНББОУС 21 нь нөхөгдөх дүнг УСНББОУС 26-гийн дагуу тодорхойлохыг байгууллагаас шаарддаг.
- ДҮ7. 2003 оны 12 дугаар сараас хойш гаргасан СТОУС-уудын үр дүнд НББОУС 16-д цаашид нэмэлт өөрчлөлт оруулсан. 2003 оны 12 дугаар сараас хойш гаргасан СТОУС-уудын үр дүн болох нэмэлт өөрчлөлтүүдийг УСНББОУС 17-д тусган оруулаагүй байна. Яагаад гэвэл, УСНББОУСЗ нь тэдгээр СТОУС-уудын шаардлагуудыг нягтлан шалгаж, улсын секторын байгууллагуудад мөрдөгдөх боломжит байдлын талаар өөрийн үзэл бодлыг хараахан илэрхийлээгүй байгаа юм.

**2008 онд гаргасан, НББОУСЗ-ийн СТОУС-ын Сайжруулалтууд-ын үр дүнд УСНББОУС 17-д хийсэн хянан засварлалт**

- ДҮ8. УСНББОУСЗ нь 2008 оны 5 дугаар сард НББОУСЗ-өөс гаргасан СТОУС-ын *Сайжруулалтууд*-д тусгасан, НББОУС 16-гийн хянан засварлалтыг нягталж шалгаад уг Стандартыг хянан засварлах болсон НББОУСЗ-ийн учир шалтгаантай ерөнхийдөө санал нийлсэн. УСНББОУСЗ нь уг нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдөхгүй байх улсын секторын тусгай учир шалтгаан байхгүй гэж дүгнэсэн.

**2012 оны 5 дугаар сар, 2013 оны 12 дугаар сар, 2014 оны 5 дугаар сард гаргасан, НББОУСЗ-ийн *СТОУС-ын Сайжруулалтууд* ба *Цар Хүрээний Цөөн Нэмэлт Өөрчлөлтүүд*-ийн үр дүнд УСНББОУС 17-д хийсэн хянан засварлалт**

ДҮ9. УСНББОУСЗ нь 2012 оны 5 дугаар сар, 2013 оны 12 дугаар сар, 2014 оны 5 дугаар сард НББОУСЗ-өөс гаргасан *СТОУС-ын Сайжруулалтууд* болон *Элэгдэл, Хорогдуулгын Хүлээн Зөвшөөрөгдөх Аргуудын Тодруулга*-д тусгасан, НББОУС 16-гийн хянан засварлалтыг нягталж шалгаад уг нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдөхгүй байх улсын секторын тусгай учир шалтгаан байхгүй гэж ерөнхийдөө санал нэгдсэн.

**УСНББОУС 2015-ын *Сайжруулалтууд*-ын Хэсэг III: “Санал гаргагчдын дэвшүүлсэн асуудлууд”-ын үр дүнд УСНББОУС 17-д хийсэн хянан засварлалт**

ДҮ10. Энхийн цагт зөвхөн сүр хүчийг үзүүлэх зорилгоор ашигладаг боловч батлан хамгаалах үйлчилгээнд байнга ашиглагдах зүйлсээс бүрдэх “зэвсгийн систем” нэр томъёог Засгийн Газрын Санхүүгийн Статистик (ЗГСС)-ийн тайлагналын зааварт ашигладаг. УСНББОУС-ын “цэргийн тусгай тоног төхөөрөмж” нэр томъёог ЗГСС-ын “зэвсгийн систем” нэр томъёогоор орлуулах ба тайлбар тодорхойлолт оруулах нь ЗГСС-ын тайлагналын заавартай нийцсэн байдлыг нэмэгдүүлэхийн зэрэгцээгээр УСНББОУС 17, *Үндсэн Хөрөнгө*-ийн мөрдөгдөх боломжит байдлыг илүү ойлгомжтой болгоно гэж УСНББОУСЗ дүгнэсэн.

ДҮ11. Зэвсгийн систем гэсэн уг санал болгосон тодорхойлолт нь хэт явцуу бөгөөд ингэснээр зэвсгийг өөртөө агуулдаггүй буюу батлан хамгаалах чадавхи боломжоор шууд хангадаг цэргийн тусгай тээврийн хэрэгсэл гэх мэт зарим хөрөнгө үүнд хамаарахгүй байж болно гэж санал гаргагч нар үзсэн. УСНББОУСЗ-ийн санал дүгнэлтээр бол, ийм тээврийн хэрэгсэл нь зэвсэгтэй эсвэл зэвсэггүй гэдгээс үл хамааран өөрийн тусгай чиг үүргийг гүйцэтгэж байвал зэвсгийн системийн тодорхойлолтонд хамаарах юм.

**2014 оны 6 дугаар сард гаргасан, НББОУСЗ-ийн *Цар Хүрээний Цөөн Нэмэлт Өөрчлөлтүүд*-ийн үр дүнд УСНББОУС 17-д хийсэн хянан засварлалт**

ДҮ12. УСНББОУСЗ нь 2014 оны 6 дугаар сард НББОУСЗ-өөс *Хөдөө Аж Ахуй: Эх Ургамал* (НББОУС 16 ба НББОУС 41-ийн Нэмэлт өөрчлөлтүүд) нэрээр гаргасан цар хүрээний цөөн нэмэлт өөрчлөлтүүдэд тусгасан, НББОУС 16-гийн хянан засварлалтыг нягталж шалгаад эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдөхгүй байх улсын секторын тусгай учир шалтгаан байхгүй гэдэгтэй ерөнхийдөө санал нийлсэн.

**2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУСЗ-ийн *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ын үр дүнд УСНББОУС 17-д хийсэн хянан засварлалт**

ДҮ13. УСНББОУСЗ нь 2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит

## ҮНДСЭН ХӨРӨНГӨ

байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (а) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р* параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

### **Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт (УСНББОУС 21 ба 26-гийн нэмэлт өөрчлөлтүүд)**

ДҮ14. УСНББОУС 21, *Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт* ба УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийн үр дүнд УСНББОУСЗ нь тухайн хөрөнгө буюу хөрөнгүүдийн бүлгийн харъяалагдах хөрөнгүүдийн нийт ангийг дахин үнэлэх шаардлага бий болгодоггүй, хөрөнгө буюу хөрөнгүүдийн бүлгийн үнэ цэнийн бууралтын гарз болон үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтын хүлээн зөвшөөрөлтийг тодорхой болгохын тулд 51А параграфыг шинээр нэмж оруулахаар шийдвэрлэсэн.



## Хэрэгжүүлэх заавар удирдамж

*Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 17-г дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний давтамж

ХЗУ1. УСНББОУС 17-гийн 44-р параграф нь тухайн тайлангийн өдрөөрх бодит үнэ цэнийг ашиглан тодорхойлох байсан дүнгээс мэдэгдэхүйц зөрүүгүй, тийм дахин үнэлсэн дүнгээр хөрөнгийг хэмжих дахин үнэлгээний загвар ашиглахыг байгууллагуудаас шаарддаг. Дахин үнэлгээний давтамж нь уг дахин үнэлж буй үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс хамаарна гэдгийг УСНББОУС 17-гийн 49-р параграфт тусгайлан заасан байдаг. Дахин үнэлсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь түүний дансны үнээс материаллаг зөрүүтэй болвол дараагийн дахин үнэлгээг хийх шаардлагатай байдаг. Энэхүү заавар удирдамжийн зорилго нь тухайн тайлангийн өдрийн бодит үнэ цэнээс дансны үнэ материаллаг зөрүүтэй эсэхийг тодорхойлохын тулд дахин үнэлгээний загвар ашиглахад байгууллагуудад туслах явдал юм.

ХЗУ2. Дахин үнэлсэн хөрөнгийн дансны үнэ нь хэрэв тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр дахин үнэлсэн бол тодорхойлогдох байсан дүнгээс материаллаг зөрүүтэй гэсэн аливаа шинж тэмдэг байгаа эсэхийг байгууллага нь тайлант үе бүрийн эцэст үнэлнэ. Хэрэв ийм аливаа шинж тэмдэг байгаа бол тухайн байгууллага нь уг хөрөнгийн бодит үнэ цэнийг тодорхойлж, хөрөнгийг тэрхүү дүнгээр дахин үнэлнэ.

ХЗУ3. Дахин үнэлсэн хөрөнгийн дансны үнэ нь хэрэв тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр дахин үнэлсэн бол тодорхойлогдох байсан дүнгээс материаллаг зөрүүтэй гэсэн аливаа шинж тэмдэг байгаа эсэхийг хянан үнэлэхдээ, тухайн байгууллага хамгийн наад зах нь дараах шинж тэмдгүүдийг харгалзан үзнэ:

#### *Мэдээллийн гадаад эх сурвалж*

- (а) Байгууллагад нөлөө үзүүлэх мэдэгдэхүйц өөрчлөлтүүд нь уг байгууллагын үйл ажиллагаагаа явуулж буй технологийн, зах зээлийн, эдийн засгийн, хуулийн орчинд эсвэл тэрхүү хөрөнгийн зориулагдах зах зээлд тухайн тайлант үеийн туршид гарч тохиолдсон буюу ойрын ирээдүйд гарч тохиолдохоор байх;
- (б) Байгууллагын хөрөнгүүдийн хувьд зах зээл оршин байгаа тохиолдолд зах зээлийн үнэ цэнэ нь тэдгээрийн дансны үнээс өөр байх;
- (в) Уг хөрөнгөнд хамаарах үнийн индекс нь тухайн тайлант үеийн туршид материаллаг өөрчлөлтөнд орсон байх;

#### *Мэдээллийн дотоод эх сурвалж*

- (г) Хөрөнгийн хоцрогдол буюу биет гэмтэл муудалтын талаархи нотолгоо бэлэн боломжтой байх;

## ҮНДСЭН ХӨРӨНГӨ

- (д) Байгууллагад нөлөө үзүүлэх мэдэгдэхүйц өөрчлөлтүүд нь хөрөнгийг ашигласан буюу ашиглахаар хүлээгдэж буй хэмжээ болон хэв маягт тухайн тайлант үеийн туршид гарч тохиолдсон буюу ойрын ирээдүйд гарч тохиолдохоор байх. Хөрөнгө ашиглагдахгүй сул зогсолт эсвэл өмнө хүлээгдэж байсан өдрөөс өмнө тухайн хөрөнгийг данснаас хасах төлөвлөгөө, хөрөнгийн ашиглалтын хугацаа тодорхой бус байсныг тодорхой болгон дахин үнэлэлт зэрэг нь сөрөг өөрчлөлтөнд хамаарна. Тухайн зарлагыг гаргахын яг өмнө үнэлсэн тэрхүү хөрөнгийн гүйцэтгэлийн стандартаас давж илүү болгох байдлаар хөрөнгийг сайжруулах буюу нэмэгдүүлэхийн тулд тайлант үеийн туршид хийсэн капитал зарлага нь тааламжтай өөрчлөлтөнд хамаарна.
- (е) Хөрөнгийн эдийн засгийн гүйцэтгэл нь хүлээгдэж байсан хэмжээтэй ижил эсвэл түүнээс сайн буюу муу эсэхийг илэрхийлэх нотолгоог дотоод тайлагналаас олж авах боломжтой байх.

ХЗУ4. Дээрх ХЗУ3-т харуулсан жагсаалтанд бүгдийг багтаан хамруулаагүй болно. Дахин үнэлсэн хөрөнгийн дансны үнэ нь хэрэв тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр дахин үнэлсэн бол тодорхойлогдох байсан дүнгээс материаллаг зөрүүтэй гэдгийг илэрхийлэх бусад шинж тэмдгүүдийг байгууллага нь тодорхойлж болох юм. Ийм нэмэлт шинж тэмдгүүдийн оршин байдал нь байгууллага тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнээр дахин үнэлэх хэрэгтэй гэдгийг бас илэрхийлнэ.

## Үлгэрчилсэн жишээ

### Тодруулга

ҮЖ1. Дотоод Засал Чимэглэлийн Хэлтэс нь төрөл бүрийн үндсэн хөрөнгийг хянаж, тухайн үндсэн хөрөнгийн орлуулалт ба засвар, үйлчилгээг хариуцдаг улсын секторын байгууллага юм. Тус байгууллагын 20X1 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн Санхүүгийн байдлын тайлангийн тодруулгаас авсан ишлэл болон энэхүү Стандартын дагуу хийх шаардлагатай үндсэн тодруулгыг доор үлгэрчлэн харуулав.

### Тодруулга

#### 1. Газар

(а) Газар нь янз бүрийн байршил дахь хорин мянган гектар талбайгаас бүрддэг. Үндэсний Үнэлгээчдийн Алба гэсэн хараат бус үнэлгээчний тодорхойлсны дагуу газрыг 20X1 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар бодит үнэ цэнээр үнэлсэн.

(б) Эрхийн хязгаарлалт:

Таван зуун гектар (62,500 мөнгөн нэгжээр бүртгэсэн) газрыг үндэсний эрх ашгийн газар гэж тодорхойлсон бөгөөд хууль тогтоогч байгууллагын зөвшөөрөлгүйгээр түүнийг борлуулж болохгүй юм. Уг үндэсний эрх ашгийн газрын хоёр зуун гектар (25,000 мөнгөн нэгжээр бүртгэсэн) хэсэг, түүнчлэн өөр хоёр мянган гектар (250,000 мөнгөн нэгжээр бүртгэсэн) газар нь хуучин эздийн зүгээс хүний эрхийн олон улсын шүүхэд гаргасан нэхэмжлэлийн улмаас эрхийн маргаантай байгаа бөгөөд Шүүх нь уг нэхэмжлэл гомдлыг шийдвэрлэх хүртэл эдгээр газрыг худалдан борлуулж болохгүй гэсэн захирамж гаргасан: Дотоод Засал Чимэглэлийн Хэлтэс нь энэхүү маргааныг хэлэлцэн шийдвэрлэх Шүүхийн хууль ёсны шийдвэрийг хүлээн зөвшөөрч байгаа.

#### 2. Барилга

(а) Барилга нь янз бүрийн байршил дахь оффисын барилга болон үйлдвэрлэлийн барилга, байгууламжаас бүрддэг.

(б) Барилгыг эхлээд өртгөөр хүлээн зөвшөөрдөг боловч тэдгээрийг тасралтгүй сууриар бодит үнэ цэнээр нь дахин үнэлэх юм. Үндэсний Үнэлгээчдийн Алба нь дахин давтагдах сууриар бодит үнэ цэнийг богино хугацааны дотор тодорхойлдог. Дахин үнэлгээ нь тухайн өдрийн байдлаар шинэчлэн баяжуулагдсан байдаг.

(в) Элэгдлийг тухайн барилгын ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцоолдог. Оффисын барилга нь хорин таван жилийн ашиглалтын хугацаатай, үйлдвэрлэлийн барилга, байгууламж нь арван таван жилийн ашиглалтын хугацаатай.

## ҮНДСЭН ХӨРӨНГӨ

- (г) Тус Хэлтэс нь шинэ барилга бариулах таван гэрээ байгуулсан бөгөөд гэрээний нийт өртөг нь 250,000 мөнгөн нэгж байна.

### **3. Машин, тоног төхөөрөмж**

- (а) Машин, тоног төхөөрөмжийг өртгөөс элэгдлийг хассан дүнгээр хэмждэг.
- (б) Элэгдлийг тухайн машин, тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцоолдог.
- (в) Машин, тоног төхөөрөмж нь янз бүрийн ашиглалтын хугацаатай:
  - Трактор: 10 жил
  - Угаах тоног төхөөрөмж: 4 жил
  - Өргөх цамхаг: 15 жил
- (г) Тус Хэлтэс нь өргөх цамхагийг байрлуулан ашигладаг барилгыг цэвэрлэх ба засвар үйлчилгээ хийхийн тулд тэрхүү өргөх цамхагийг сольж орлуулах гэрээ байгуулсан. Гэрээний өртөг нь 100,000 мөнгөн нэгж байна.

### **4. Тавилга, эд хогшил**

- (а) Тавилга, эд хогшлыг өртгөөс элэгдлийг хассан дүнгээр хэмждэг.
- (б) Элэгдлийг тухайн тавилга, эд хогшлын ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцоолдог.
- (в) Энэхүү анги доторх бүх зүйлс нь таван жилийн ашиглалтын хугацаатай.

ҮНДСЭН ХӨРӨНГӨ

**Тохируулга**  
(мянган мөнгөн нэгжээр)

	Газар		Барилга		Машин, тоног төхөөрөмж		Тавилга, эд хогшил	
	20X1	20X0	20X1	20X0	20X1	20X0	20X1	20X0
Тайлант үе	2,250	2,025	2,090	2,260	1,085	1,100	200	150
Эхний үлдэгдэл	-	-	250	100	120	200	20	100
Нэмэгдэлт	-	-	150	40	60	80	20	-
Данснаас хасалт	-	-	160	180	145	135	50	50
Элэгдэл (Санхүүгийн үр дүнийн тайланд тусгаснаар)								
Дахин үнэлгээ (цэвэр дүн)	250	225	-30	-50	-	-	-	-
Эцсийн үлдэгдэл (Санхүүгийн байдлын тайланд тусгаснаар)	2,500	2,250	2,000	2,090	1,000	1,085	150	200
Дахин үнэлгээний нэмэгдлийн нийт дүн (92(е) параграф)	750	500	250	250	-	-	-	-
Дахин үнэлгээний бууралтын нийт дүн (92(ж) параграф)	25	25	380	350	-	-	-	-
Дансны нийт үнэ	2,500	2,250	2,500	2,430	1,500	1,440	250	250
Хуримтлагдсан элэгдэл	-	-	500	340	500	355	100	50
Дансны цэвэр үнэ	2,500	2,250	2,000	2,090	1,000	1,085	150	200

## НББОУС 16-ТАЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 17-г НББОУС 16, *Үндсэн Хөрөнгө* (2003)-өөс үндсэндээ бэлтгэсэн бөгөөд 2008 оны 5 дугаар сард гаргасан, *СТОУС-ын Сайжруулалтууд*-ын нэг хэсэг байдлаар НББОУС 16-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг үүнд тусгасан болно. Энэ Стандартыг гаргах үед УСНББОУСЗ нь улсын секторын байгууллагуудад *СТОУС 5, Борлуулах Зорилгоор Эзэмшиж Буй Эргэлтийн Бус Хөрөнгө ба Зогсоосон Үйл Ажиллагаа*-ны мөрдөгдөх боломжтой байдлыг харгалзан үзээгүй байсан; иймээс *СТОУС 5*-ыг гаргасны үр дүнд НББОУС 16-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг УСНББОУС 17-д тусгаагүй. УСНББОУС 17 ба НББОУС 16 (2003)-гийн хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- УСНББОУС 17 нь соёлын өв хөрөнгийг хүлээн зөвшөөрөхийг шаарддаггүй эсвэл хориглодоггүй. Соёлын өв хөрөнгийг хүлээн зөвшөөрдөг байгууллага нь уг хүлээн зөвшөөрсөн соёлын өв хөрөнгийн хувьд энэ Стандартын тодруулгын шаардлагуудыг даган мөрдөх ёстой боловч тэдгээр соёлын өв хөрөнгийн хувьд энэ Стандартын бусад шаардлагуудыг мөрдөх албагүй юм. НББОУС 16-д ийм гажих нөхцөл байхгүй.
- НББОУС 16 нь үндсэн хөрөнгийн зүйлсийг эхлээд өртгөөр хэмжихийг шаарддаг. Тухайн зүйлийг үнэгүй буюу нэрлэсэн өртгөөр олж эзэмшсэн тохиолдолд түүний өртөг нь тэрхүү олж эзэмшсэн өдрөөрх бодит үнэ цэнэ байна гэж УСНББОУС 17-д заасан. Байгууллага нь дахин үнэлгээний загварыг хэрэглэдэг бөгөөд үндсэн хөрөнгийн зүйлсийг уг дахин үнэлсэн дүнгээр бүртгэдэг тохиолдолд түүхэн өртөгтэй адилтгах дүнг тодруулахыг НББОУС 16-гаар шаарддаг. Ийм шаардлагыг УСНББОУС 17-д тусган оруулаагүй.
- НББОУС 16-д заасны дагуу дахин үнэлгээний нэмэгдэл ба бууралтыг зөвхөн бие даасан зүйл нэг бүрээр харгалзуулж болох юм. Харин УСНББОУС 17-гийн дагуу дахин үнэлгээний нэмэгдэл ба бууралтыг тухайн хөрөнгийн ангид үндэслэн харилцан суутгаж, цэвэр дүнг гаргадаг.
- УСНББОУС 17 нь анх удаа мөрдөлт, түүнчлэн УСНББОУС 17-гийн өмнөх хувилбарт орсон өөрчлөлтийн аль алинд хамаарах шилжилтийн нөхцлүүдийг агуулсан байдаг. Харин НББОУС 16 нь *СТОУС*-уудыг аль хэдийн мөрдөж буй аж ахуйн нэгжүүдэд хамаарах шилжилтийн нөхцлүүдийг зөвхөн агуулсан байдаг. Тухайлбал; УСНББОУС 17 нь УСНББОУС-уудын дагуу аккруэл суурьт нягтлан бодох бүртгэлийг анх мөрдсөн өдрөөс хойшхи таван жилийн хугацааны дотор эхлэх тайлант үеүдийн хувьд үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрөхгүй байхыг байгууллагуудад зөвшөөрсөн шилжилтийн нөхцлүүдтэй байдаг. Энэ Стандартыг анх мөрдөхдөө, байгууллага нь үндсэн хөрөнгийг түүний бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөхийг уг шилжилтийн нөхцлүүдээр бас зөвшөөрдөг. НББОУС 16-д ийм шилжилтийн нөхцлүүд байдаггүй.

## ҮНДСЭН ХӨРӨНГӨ

- УСНББОУС 17 нь “мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз” ба “нөхөгдөх үйлчилгээний дүн”-гийн тодорхойлолтыг агуулсан байдаг. НББОУС 16-д эдгээр тодорхойлолт байдаггүй.
- УСНББОУС 17 нь зарим тохиолдолд НББОУС 16-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь УСНББОУС 17 дахь “санхүүгийн үр дүнгийн тайлан” ба “цэвэр хөрөнгө/өмч” гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. НББОУС 16 дахь адилтгах нэр томъёо нь “орлогын тайлан” ба “өмч” юм.
- НББОУС 16-гийн хувьд “орлого” /revenue/ нэр томъёоноос илүү өргөн утгатай байдаг “орлого” /income/ нэр томъёог УСНББОУС 17-д ашигладаггүй.
- УСНББОУС 17 нь үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний давтамжийн талаархи Хэрэгжүүлэх Заавар Удирдамжийг агуулсан байдаг. НББОУС 16-д үүнтэй адилтгах заавар удирдамж байдаггүй.

## УСНББОУС 18–СЕГМЕНТИЙН ТАЙЛАГНАЛ

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) 14, *Сегментийн Тайлагнал* (1997 онд хянан засварласан)-аас үндсэндээ бэлтгэсэн болно. НББОУС 14-өөс авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон EC4M 6XH, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)

Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.



## УСНББОУС 18-СЕГМЕНТИЙН ТАЙЛАГНАЛ

### УСНББОУС-ын түүх

Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

УСНББОУС 18, Сегментийн Тайлагнал-ыг 2002 оны 6 дугаар сард гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 18-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл (2017 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 37, Хамтын Хэлэлцээр (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 35, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 3, Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа (2006 оны 12 дугаар сард гаргасан)
- УСНББОУС 17, Үндсэн Хөрөнгө (2006 оны 12 дугаар сард гаргасан)
- УСНББОУС-ын Сайжруулалтууд (2010 оны 11 дүгээр сард гаргасан)

### УСНББОУС 18-ын нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт

Өөрчлөгдсөн параграф	Хэрхэн өөрчилсөн	Юугаар өөрчилсөн
2	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
3	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
16	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
24	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
27	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар УСНББОУС 3, 2006 оны 12-р сар
32	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар

СЕГМЕНТИЙН ТАЙЛАГНАЛ

34	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
37	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 17, 2006 оны 12-р сар УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
38	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
41	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
57	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 3, 2006 оны 12-р сар
69	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 3, 2006 оны 12-р сар УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
70	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 3, 2006 оны 12-р сар
76А	Шинэ	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
76Б	Шинэ	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар
76В	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
76Г	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
76Д	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
77	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
ҮЖ	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 3, 2006 оны 12-р сар УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар

## УСНББОУС 18–СЕГМЕНТИЙН ТАЙЛАГНАЛ

## АГУУЛГА

	Параграф
Зорилго	
Цар хүрээ	1-7
Тодорхойлолт	8-11
Сегментээр тайлагнах	12-26
Тайлагналын бүтэц	14-16
Үйлчилгээний сегмент ба газар зүйн сегмент	17-22
Олон сегментээр ангилах	23
Тайлагналын бүтцийн тохиромжгүй байдал	24-26
Сегментийн орлого, зардал, хөрөнгө, өр төлбөрийн болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодорхойлолт	27-42
Сегментэд хамаарах зүйлс	28-32
Сегментийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зардал	33-42
Сегментийн нягтлан бодох бүртгэлийн бодлого	43-46
Хамтын хөрөнгө	47-48
Шинээр тодорхойлсон сегмент	49-50
Тодруулга	51-75
Сегментийн нэмэлт мэдээлэл	65-66
Тодруулгын бусад асуудлууд	67-73
Сегментийн үйл ажиллагааны зорилтууд	74-75
Хүчин төгөлдөр болох хугацаа	76-77
Дүгнэлтийн үндэслэл	
Хэрэгжүүлэх заавар удирдамж	
Үлгэрчилсэн жишээ	
НББОУС 14-тэй харьцуулалт	

## СЕГМЕНТИЙН ТАЙЛАГНАЛ

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 18, *Сегментийн Тайлагнал*-ыг түүний зорилго хэсэг болон 1-77-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 18-ыг түүний зорилгын агуулга, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

Энэ Стандартын зорилго нь санхүүгийн мэдээллийг сегментүүдээр тайлагнах зарчмуудыг тогтооход оршино. Ийм мэдээллийн тодруулга нь:

- (а) Байгууллагын өнгөрсөн үр дүнг илүү сайн ойлгох ба тухайн байгууллагын гол үйл ажиллагааг эрхлэн явуулахын тулд хуваарилсан нөөцийг тодорхойлоход санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд туслах; ба
- (б) Санхүүгийн тайлагналын ил тод, ойлгомжтой байдлыг нэмэгдүүлэх ба тухайн байгууллага өөрийн үүрэг, хариуцлагаа илүү сайн биелүүлэх боломж олгоно.

## Цар хүрээ

1. **Нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь сегментийн мэдээллийн толилуулгад энэ Стандартыг мөрдөнө.**
2. [Хассан]
3. [Хассан]
4. **УСНББОУС-уудад нийцүүлэн нийтлэх иж бүрэн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.**
5. УСНББОУС 1-д заасанчлан, иж бүрэн санхүүгийн тайлан нь санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон тодруулгаас бүрдэнэ.
6. **Засгийн газрын буюу эдийн засгийн нэгдмэл бусад байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлан ба толгой байгууллагын тусдаа санхүүгийн тайлангийн аль алиныг хамтад нь толилуулдаг бол сегментийн мэдээллийг зөвхөн уг нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн толилуулах шаардлагатай.**
7. Зарим улс оронд, засгийн газрын буюу эдийн засгийн нэгдмэл бусад байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлан ба хяналт тавигч байгууллагын тусдаа санхүүгийн тайланг эмхтгэн бүрдүүлж, хамтад нь нэг тайлан илтгэл байдлаар толилуулдаг. Ингэж нэг тайлан илтгэл байдлаар толилуулдаг тохиолдолд засгийн газрын буюу хяналт тавигч бусад байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланг агуулсан тайлан илтгэл нь зөвхөн уг нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд сегментийн мэдээллийг толилуулах шаардлагатай байдаг.

## Тодорхойлолт

8. [Хассан]

9. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

**Сегмент** гэдэг нь (а) өөрийн зорилтуудад хүрэхдээ тухайн байгууллагын хийсэн өнгөрсөн гүйцэтгэлийг үнэлэх, ба (б) нөөцийн ирээдүйн хуваарилалтын талаар шийдвэр гаргах зорилгоор түүний хувьд санхүүгийн мэдээллийг тусад нь тайлагнахад тохиромжтой тухайн байгууллагын ялган тодорхойлж болох үйл ажиллагаа буюу үйл ажиллагаануудын бүлэг юм.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д дахин нийтэлсэн болно.

10. Засгийн газар болон түүний агентлагууд нь улсын томоохон нөөцийг хянаж, газар зүйн янз бүрийн бүс нутаг болон нийгэм-эдийн засгийн өөр өөр шинж чанар бүхий бүс нутгийн оршин суугчдыг төрөл бүрийн бараа, үйлчилгээгээр хангахын тулд үйл ажиллагаагаа явуулдаг. Эдгээр байгууллагууд нь өөрийн зорилтонд хүрэхийн тулд тэрхүү нөөцийг үр ашигтай, үр дүнтэй ашиглана гэж тэднээс хүлээдэг бөгөөд зарим тохиолдолд тэднээс албан ёсоор ингэж шаарддаг. Байгууллагын хэмжээний болон нэгтгэсэн санхүүгийн тайлан нь дараах зүйлсийн талаархи тойм мэдээгээр хангадаг. Үүнд: (а) уг тайлагнагч байгууллагын хянаж буй хөрөнгө ба хариуцах өр төлбөр, (б) үзүүлсэн үйлчилгээний өртөг, (в) тэдгээр үзүүлэх үйлчилгээг санхүүжүүлэхийн тулд бий болгосон татварын орлого, төсвийн хуваарилалт болон өртгийн нөхөлтүүд. Гэвч энэхүү нэгтгэн нийлүүлсэн мэдээлэл нь уг тайлагнагч байгууллагын үйл ажиллагааны тусгай зорилтууд болон гол үйл ажиллагаа, түүнд зориулагдсан нөөц, тэдгээр зорилтуудын болон үйл ажиллагааны өртөг зардлын талаархи мэдээллээр хангадаггүй.
11. Ихэнх тохиолдолд байгууллагын үйл ажиллагаа нь үүрэг хариуцлага ба шийдвэр гаргалтын зорилгын хувьд холбогдох мэдээллээр хангахын тулд түүний тухайн тодорхой сегментүүдийн талаар салган задалсан санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг тайлагнах шаардлагатай болохуйц маш өргөн хүрээтэй байдаг бөгөөд газар зүйн янз бүрийн өргөн бүс нутаг буюу нийгэм-эдийн засгийн өөр өөр шинж чанар бүхий бүс нутгуудыг өөртөө агуулсан байдаг.

## Сегментээр тайлагнах

12. **Байгууллага нь өөрийн тусдаа сегментүүдийг энэ Стандартын 9-р параграфын шаардлагуудад нийцүүлэн тодорхойлох бөгөөд энэ Стандартын 51-75-р параграфтаар шаардсанчлан, тэдгээр сегментүүдийн талаархи мэдээллийг толилуулна.**
13. (а) өөрийн зорилтуудад хүрэхдээ тухайн байгууллагын хийсэн өнгөрсөн гүйцэтгэлийг үнэлэх, ба (б) тухайн байгууллагын нөөцийн хуваарилалтын

## СЕГМЕНТИЙН ТАЙЛАГНАЛ

талаар шийдвэр гаргах зорилгоор түүний хувьд санхүүгийн мэдээллийг тайлагнавал зохих, ялган тодорхойлж болох үйл ажиллагаа буюу үйл ажиллагаануудын бүлэг нэг бүрийг улсын секторын байгууллагууд нь энэ Стандартын дагуу тусдаа сегмент гэж тодорхойлно. Энэ Стандартын 51-75-р параграфтаар шаардсан мэдээллийн тодруулгаас гадна, байгууллагууд нь энэ Стандартаар тодорхойлсон эсвэл үүрэг хариуцлагын болон шийдвэр гаргах зорилгын хувьд шаардлагатай гэж үзсэн уг тайлагнасан сегментүүдийн талаархи нэмэлт мэдээллийг бас тодруулахыг дэмжинэ.

### Тайлагналын бүтэц

14. Төсвийн баримт бичигт тодорхойлсон үйл ажиллагааны гол ангилалууд нь тухайн байгууллагын удирдах зөвлөл болон хамгийн дээд түвшний менежерт мэдээллийг нь тайлагнадаг тийм сегментүүдийг ихэнх тохиолдолд тусган илэрхийлдэг. Удирдах зөвлөл болон дээд түвшний менежерт тайлагнадаг сегментүүд нь ихэнх тохиолдолд мөн санхүүгийн тайланд тайлагнасан сегментүүдийг тусган илэрхийлдэг. Яагаад гэвэл, удирдах зөвлөл болон дээд түвшний менежер нь сегментүүдийн талаархи бөгөөд дараах боломжийг тэдэнд олгох мэдээллийг шаарддаг: (а) удирдах үүрэг хариуцлагаа биелүүлэх ба өөрийн зорилтуудад хүрэхдээ тухайн байгууллагын хийсэн өнгөрсөн гүйцэтгэлийг үнэлэх, ба (б) тухайн байгууллагын нөөцийн ирээдүйн хуваарилалтын талаар шийдвэр гаргах.
15. Үүрэг хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгоор тусдаа сегментүүд гэж бүлэглэх ба санхүүгийн тайланд тайлагнавал зохих үйл ажиллагааг тодорхойлохдоо шүүн тунгаалт хийдэг. Санхүүгийн тайланг бэлтгэгч нар нь ийм шүүн тунгаалт хийхдээ дараах гэх мэт асуудлуудыг харгалзан үзнэ:
  - (а) Дээрх 9-р параграфт тодорхойлсончлон, санхүүгийн мэдээллийг сегментээр тайлагнах зорилго;
  - (б) Байгууллагын гол үйл ажиллагааны талаархи тухайн нийгмийн гишүүд болон тэдний сонгосон буюу томилсон төлөөлөгчдийн хүлээлт;
  - (в) *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал*-д тодорхойлсон, санхүүгийн тайлагналын чанарын шинжүүд; ба
  - (г) Удирдах зөвлөл болон дээд түвшний менежер нь өөрийн зорилтуудад хүрэхдээ уг байгууллагын хийсэн өнгөрсөн гүйцэтгэлийг үнэлэх, ирээдүйд зорилгодоо хүрэхийн тулд байгууллагын нөөцийн хуваарилалтын талаар шийдвэр гаргах боломжийг тэдэнд олгох санхүүгийн мэдээллийг шаардах тийм суурь үндэслэлийг тухайн сегментийн бүтцэд тусгадаг эсэх.
16. Нийт засгийн газрын түвшинд санхүүгийн мэдээллийг ихэвчлэн нэгтгэн нийлүүлж, тухайлбал, дараах зүйлсийг тусгах тийм арга маягаар тайлагнадаг:

## СЕГМЕНТИЙН ТАЙЛАГНАЛ

- (a) Эрүүл мэнд, боловсрол, батлан хамгаалах, нийгмийн хамгаалал (эдгээр нь Засгийн Газрын Санхүүгийн Статистик (ЗГСС) дахь засгийн газрын чиг үүргийн ангиллыг тусгаж болох юм) гэх мэт төв засгийн газрын эрхэлдэг үйл ажиллагааны эдийн засгийн гол ангилал, түүнчлэн төрийн өмчит цахилгаан станц, банк, даатгалын байгууллага гэх мэт улсын секторын худалдаа арилжааны байгууллагуудын эрхэлдэг худалдаа арилжааны гол үйл ажиллагаа; эсвэл
- (б) Бие даасан сайдууд буюу гүйцэтгэх засаглалын гишүүдийн багцын хариуцлага. Эдгээр нь дээрх (a)-д дурдсан, эдийн засгийн ангиллыг байнга биш боловч ихэнх тохиолдолд тусгадаг – Багцын хариуцлага нь эдийн засгийн нэгээс олон ангиллыг нэгтгэн нийлүүлэх буюу тэдгээр ангиллыг дамнан хамарч болох учраас зөрүү үүсэж болно.

### Үйлчилгээний сегмент ба газар зүйн сегмент

- 17. Байгууллагын удирдах зөвлөл болон дээд түвшний менежерт тайлагнасан сегментийн төрлүүдийг ихэвчлэн үйлчилгээний сегмент эсвэл газар зүйн сегмент гэж нэрлэдэг. Эдгээр нэр томъёог энэ Стандартад доор дурдсан утгаар ойлгож, хэрэглэнэ:
  - (a) Үйлчилгээний сегмент гэдэг нь холбогдох гарц бүтээгдэхүүнийг нийлүүлэх буюу байгууллага нэг бүрийн эрхэм зорилготой нийцсэн тухайн тодорхой үйл ажиллагааны зорилтуудад хүрэхийн тулд үйл ажиллагаа эрхэлдэг уг байгууллагын ялган тодорхойлж болох бүрэлдэхүүн хэсэг юм; ба
  - (б) Газар зүйн сегмент гэдэг нь холбогдох гарц бүтээгдэхүүнийг нийлүүлэх буюу тодорхой газар зүйн бүсийн хүрээнд тухайн тодорхой үйл ажиллагааны зорилтуудад хүрэхийн тулд үйл ажиллагаа эрхэлдэг уг байгууллагын ялган тодорхойлж болох бүрэлдэхүүн хэсэг юм.
- 18. Үйлчилгээний төрөл нь (a) үндсэн гарц бүтээгдэхүүнийг тодорхойлох, (б) тэдгээрийн амжилт гүйцэтгэлийг хянан үнэлэх, (в) тэдний нөөцийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж төсөвлөх арга замыг тусгадаг учраас засгийн газрын хэлтэс, агентлагуудыг ихэвчлэн үйлчилгээний төрлийн дагуу удирдан зохицуулдаг. Үйлчилгээний төрөл буюу үйлчилгээний сегментэд үндэслэн дотооддоо тайлагнадаг байгууллагын жишээ нь; зохион байгуулалтын бүтэц ба дотоод тайлагналын систем нь анхан, дунд, ахисан түвшний боловсрол олгох үйл ажиллагаа болон гарц бүтээгдэхүүнийг тусдаа сегментүүд гэж тусгадаг боловсролын байгууллага юм. Боловсролын ийм өргөн хүрээтэй үйл ажиллагаа нэг бүрийн хувьд хүссэн гарц, үр дүнг бий болгоход шаардлагатай ур чадвар болон арга хэрэгсэл өөр өөр байх учраас сегментчлэлийн энэхүү суурийг дотооддоо ашиглаж болох юм. Түүнчлэн, удирдлагын гаргах шаардлагатай санхүүгийн гол шийдвэр нь тэдгээр гарц буюу үйл ажиллагаа нэг бүрд хуваарилах нөөцийн тодорхойлолт юм. Ийм тохиолдолд үйлчилгээний сегментүүдэд үндэслэн гаднын зориулалтаар тайлагнах нь энэ Стандартын шаардлагыг мөн хангана.



## СЕГМЕНТИЙН ТАЙЛАГНАЛ

19. Гарц бүтээгдэхүүнүүд (бараа, үйлчилгээ) нь хамааралтай бөгөөд санхүүгийн тайлагналын зорилгоор сегмент гэж бүлэглэх эсэхийг тодорхойлохдоо харгалзан үзэх хүчин зүйлсэд дараах зүйлс хамаарна:
- (а) Байгууллагын үйл ажиллагааны анхдагч зорилго ба тэдгээр зорилго нэг бүрд хүрэхтэй холбоотой бараа, үйлчилгээ, үйл ажиллагаа, түүнчлэн бараа, үйлчилгээний бүлгүүдэд үндэслэн нөөцийг хуваарилдаг ба төсөвлөдөг эсэх;
  - (б) Нийлүүлэх бараа, үйлчилгээ буюу гүйцэтгэх үйл ажиллагааны шинж төрөл;
  - (в) Үйлдвэрлэлийн процесс ба/буюу үйлчилгээний нийлүүлэлт, түгээн хуваарилалтын процесс буюу механизмын шинж төрөл;
  - (г) Бараа, үйлчилгээний худалдан авагч буюу хэрэглэгчдийн төрөл;
  - (д) Энэ нь байгууллагыг удирдан зохицуулах, дээд түвшний удирдлага болон удирдах зөвлөлд санхүүгийн мэдээллийг тайлагнах арга замыг тусгадаг эсэх;
  - (е) Хэрэв хамааралтай бол зохицуулалтын орчин (жишээлбэл; хэлтсийн буюу хууль хуулиар олгогдсон бүрэн эрх) буюу засгийн газрын сектор (жишээлбэл; санхүүгийн сектор, нийтийн аж ахуй, төв засгийн газар)-ын шинж төрөл.
20. Үндэсний, мужийн, орон нутгийн болон засаг захиргааны бусад нэгжийн хил хязгаарын дотор эсвэл хил хязгаарыг дамнасан эсэхээс үл хамааран байгууллага нь бүс нутагт үндэслэн зохион байгуулагдаж, өөрийн удирдах зөвлөл болон дээд түвшний менежерт дотооддоо тайлагнадаг байж болно. Ийм тохиолдолд уг дотоод тайлагналын систем нь газар зүйн сегментийн бүтцийг тусгадаг.
21. Удирдах зөвлөл ба дээд түвшний менежерийн хийх гол гүйцэтгэлийн үнэлгээ болон нөөцийн хуваарилалтын шийдвэрийг бүс нутгийн амжилт үр дүн, бүс нутгийн хэрэгцээ шаардлагыг харгалзан тодорхойлдог учраас тухайлбал, боловсролын хэлтсийн зохион байгуулалтын бүтэц ба тайлагналын систем нь тухайн бүс нутгийн боловсролын гарц үр дүнд үндэслэдэг тохиолдолд газар зүйн сегментийн бүтцийг ашиглан мөрдөж болох юм. Боловсролын хэрэгцээ шаардлага болон боловсролын үйлчилгээний нийлүүлэлтийн хувьд орон нутгийн бие даасан байдлыг хадгалах эсвэл үйл ажиллагааны нөхцөл байдал болон боловсролын зорилтууд нь нэг бүс нутгаас нөгөө бүс нутагт эрс өөр байдгийн улмаас ийм бүтцийг ашиглаж болно. Мөн түүнчлэн, хариуцлагыг бүс нутагт шилжүүлэх тийм зохион байгуулалтын бүтэц нь тухайн байгууллагын зорилтуудад илүү сайн үйлчилнэ гэж удирдлага үзсэн учраас ийм бүтцийг зүгээр л хэрэглэдэг байж болох юм. Ийм тохиолдолд удирдах зөвлөл болон дээд түвшний менежер нь нөөцийн хуваарилалтын шийдвэрийг бүс нутагт үндэслэн эхлээд гаргах ба дараа нь хянан үнэлдэг. Газар зүйн бүс нутгийн хүрээн дэх тодорхой чиг үүргийн үйл ажиллагаануудад нөөцийг хуваарилах талаархи илүү нарийвчилсан шийдвэрийг тухайн орон нутгийн удирдлага нь тэрхүү бүсийн боловсролын хэрэгцээ шаардлагад

## СЕГМЕНТИЙН ТАЙЛАГНАЛ

нийцүүлэн дараа нь гаргадаг. Ийм тохиолдолд мэдээллийг санхүүгийн тайланд газар зүйн сегментээр ангилан тусгах уг тайлагнал нь энэ Стандартын шаардлагуудыг бас хангах юм.

22. Санхүүгийн мэдээллийг газар зүйн байршилд үндэслэн тайлагнах эсэхийг тодорхойлохдоо дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ:
- (а) Өөр өөр бүс нутаг дахь эдийн засаг, нийгэм, улс төрийн нөхцөл байдлын ижил төсөөтэй байдал;
  - (б) Тухайн байгууллагын болон янз бүрийн бүс нутгийн анхдагч зорилтуудын хоорондох харилцаа холбоо;
  - (в) Үйлчилгээний нийлүүлэлтийн шинж чанарууд ба үйл ажиллагааны нөхцөл байдлууд нь өөр өөр бүс нутагт ялгаатай байдаг эсэх;
  - (г) Энэ нь тухайн байгууллагыг удирдан зохицуулах ба түүний санхүүгийн мэдээллийг дээд түвшний менежерүүд болон удирдах зөвлөлд тайлагнах арга замыг тусгадаг эсэх; ба
  - (д) Тухайн бүс нутаг дахь үйл ажиллагаатай холбоотой тусгай хэрэгцээ шаардлага, ур чадвар буюу эрсдэл.

### **Олон сегментээр ангилах**

23. Зарим тохиолдолд байгууллага нь нэгээс олон сегментийн бүтцэд тухайлбал, үйлчилгээний ба газар зүйн сегментийн аль алинд үндэслэн сегментийн орлого, зардал, хөрөнгө, өр төлбөрийг өөрийн удирдах зөвлөл болон дээд түвшний менежерт тайлагнаж болох юм. Байгууллагын зорилтуудын биелэлтэнд түүний нийлүүлдэг төрөл бүрийн бүтээгдэхүүн, үйлчилгээ ба тэдгээр бараа, үйлчилгээг ханган нийлүүлэх газар зүйн янз бүрийн бүс нутгийн аль аль нь хүчтэй нөлөө үзүүлдэг бол гаднын зориулалттай санхүүгийн тайланд үйлчилгээний болон газар зүйн сегментийн аль алинд үндэслэн тайлагнаснаар чухал ач холбогдолтой мэдээллээр ихэвчлэн хангадаг. Үүнтэй адилаар, нийт засгийн газрын түвшинд засгийн газар нь дараах тодруулгын суурийг мөрдөж болох юм: (а) төв засгийн газар, улсын санхүүгийн сектор, худалдаа арилжааны секторын тодруулгыг тусгах, ба (б) төв засгийн газрын секторын шинжилгээг тухайлбал, гол зорилго буюу чиг үүргийн дэд ангилалуудын сегментийн тодруулгаар дэмжин баяжуулах. Энэ тохиолдолд сегментүүдийг тусад нь, эсвэл матриц хэлбэрээр тайлагнаж болно. Мөн түүнчлэн, хоёрдогч сегментийн талаар зөвхөн хязгаарлагдмал тодруулга хийснээр анхдагч болон хоёрдогч сегментийн тайлагналын бүтцийг ашиглаж болох юм.

### **Тайлагналын бүтцийн тохиромжгүй байдал**

24. Дээр дурдсанчлан, тухайн байгууллагын өнгөрсөн гүйцэтгэлийг үнэлэх ба нөөцийн ирээдүйн хуваарилалтын талаар шийдвэр гаргах зорилгоор уг байгууллагын удирдах зөвлөлд болон хамгийн дээд түвшний менежерт мэдээллийг нь дотооддоо тайлагнадаг сегментүүд нь ихэнх тохиолдолд төсвийн баримт бичигт тодорхойлсон ба мөн энэ Стандартын

## СЕГМЕНТИЙН ТАЙЛАГНАЛ

шаардлагуудын дагуу гадаад тайлагналын зорилгоор бас ашигладаг тийм сегментүүдийг тусгадаг. Гэвч зарим тохиолдолд тухайн байгууллагын удирдах зөвлөл болон дээд түвшний менежерт тайлагнадаг түүний дотоод тайлагналыг дараах байдлаар бүтэцчлэн зохион байгуулж болно. Үүнд: төсвөөс хамааралтай үйл ажиллагаатай холбоотой орлого, зардал, хөрөнгө, өр төлбөрийг худалдаа арилжааны үйл ажиллагаатай холбоотой орлого, зардал, хөрөнгө, өр төлбөрөөс ялган зааглах, эсвэл төсвөөс хамааралтай байгууллагуудыг улсын секторын худалдаа арилжааны байгууллагуудаас ялган зааглах. Зөвхөн ийм сегментүүдэд үндэслэн санхүүгийн тайланд сегментийн мэдээллийг тайлагнах нь энэ Стандартын хувьд тусгайлан заасан зорилтуудыг ханган биелүүлэх магадлал багатай байдаг. Яагаад гэвэл, эдгээр сегментүүд нь хамааралтай мэдээллээр, тухайлбал өөрийн үйл ажиллагааны гол зорилтуудад хүрэхдээ тухайн байгууллагын хийсэн өнгөрсөн гүйцэтгэлийн талаархи мэдээллээр хэрэглэгчдийг хангах магадлал багатай байдаг. *УСНББОУС 22, Засгийн Газрын Үндсэн Секторын Талаархи Санхүүгийн Мэдээллийн Тодруулга* нь статистикийн тайлагналын суурьт тодорхойлсон засгийн газрын үндсэн сектор (ЗГҮС)-ын талаархи санхүүгийн мэдээллийг тодруулах сонголт хийсэн засгийн газруудад хамаарах шаардлагуудыг тусгасан байдаг.

25. Зарим тохиолдолд, удирдах зөвлөл болон дээд түвшний менежерт тайлагнах, салган задалсан санхүүгийн мэдээлэл нь үйлчилгээний сегмент, газар зүйн сегмент эсвэл бусад үйл ажиллагаагаар ангилсан зардал, орлого, хөрөнгө, өр төлбөрийг тайлагнадаггүй байж болох юм. Ийм тайланг зөвхөн төсвийн хуваарилалт буюу тухайн байгууллагад хэрэглэж болох бусад санхүүжилтийн буюу зарлагын зөвшөөрлийн загварт нийцсэн мөрийн зүйлсэд үндэслэн, зарлагын төрлийг (жишээлбэл; цалин хөлс, түрээс, хангамж, капитал худалдан авалт) тусгах байдлаар бүтэцчлэн зохион байгуулж болно. Удирдах зөвлөл болон дээд түвшний удирдлагад танилцуулах санхүүгийн тайлагнал нь (а) өөрийн зорилтуудад хүрэх тухайн байгууллагын гол үйл ажиллагааны өнгөрсөн гүйцэтгэлийг үнэлэх, ба (б) нөөцийн ирээдүйн хуваарилалтын талаар шийдвэр гаргах биш, харин олгогдсон зарцуулалтын эрхэд нийцүүлсэн гэдгээ нотлон харуулах зорилготой байх үед ийм тохиолдол үүсэж болох юм. Удирдах зөвлөл болон дээд түвшний менежерт танилцуулах дотоод тайлагнал нь зөвхөн ийм нийцлийн мэдээллийг тайлагнах байдлаар бүтэцчлэн зохион байгуулагдсан тохиолдолд уг удирдах зөвлөл болон дээд түвшний менежерт хүргэх дотоод тайлагналтай ижил сууриар гаднын талуудад хүргэх тайлагнал нь энэ Стандартын шаардлагуудыг хангахгүй юм.
26. Байгууллагын дотоод тайлагналын бүтэц нь энэ Стандартын шаардлагуудыг тусгадаггүй тохиолдолд гадаад тайлагналын зорилгоор байгууллага нь 9-р параграфт дурдсан, сегментийн тодорхойлолтыг хангах тийм сегментүүдийг тодорхойлох ба 51-75-р параграфтаар шаардсан, мэдээллийг тодруулах шаардлагатай юм.

## Сегментийн орлого, зардал, хөрөнгө, өр төлбөрийн болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодорхойлолт

27. Энэ Стандартад дараах нэмэлт нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

Сегментийн нягтлан бодох бүртгэлийн бодлого гэдэг нь нэгтгэсэн групп буюу байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж, толилуулахад мөрддөг нягтлан бодох бүртгэлийн бодлого, түүнчлэн сегментийн тайлагналд тусгайлан хамаарах тийм нягтлан бодох бүртгэлийн бодлого юм.

Сегментийн хөрөнгө гэдэг нь сегмент өөрийн үндсэн үйл ажиллагаандаа ашигладаг болон тухайн сегментэд шууд хамааруулж болох эсвэл ул үндэслэлтэй сууриар түүнд хуваарилж болох үйл ажиллагааны хөрөнгө юм.

Хэрэв сегментийн орлогод хүүний буюу ногдол ашгийн орлого хамаардаг бол түүний сегментийн хөрөнгөнд холбогдох авлага, зээл, хөрөнгө оруулалт буюу орлого бий болгох бусад хөрөнгө хамаарна.

Орлогын татвар буюу орлогын татвартай адилтгах татвар төлөх үүргийг бүртгэн тайлагнах нягтлан бодох бүртгэлийн стандартуудын дагуу хүлээн зөвшөөрдөг орлогын татвар буюу орлогын татвартай адилтгах хөрөнгүүд нь сегментийн хөрөнгөнд хамаарахгүй.

Өмчийн аргаар тайлагнадаг хөрөнгө оруулалтын цэвэр ашгийг (алдагдлыг) сегментийн орлогод тусган оруулдаг зөвхөн тэр тохиолдолд ийм хөрөнгө оруулалт нь сегментийн хөрөнгөнд хамаарна.

Тухайн байгууллагын санхүүгийн байдлын тайланд шууд суутган тооцох байдлаар тайлагнадаг, холбогдох хасагдуулгыг хассаны дараа сегментийн хөрөнгийг тодорхойлно.

Сегментийн зардал гэдэг нь сегментийн үндсэн үйл ажиллагаанаас үүссэн ба уг сегментэд шууд хамааруулж болох зардал, ул үндэслэлтэй сууриар сегментэд хуваарилж болох зардлын холбогдох хэсэг, үүн дотроо гаднын талуудад бараа, үйлчилгээ нийлүүлэхтэй холбоотой зардал, тухайн байгууллагын бусад сегментүүдтэй хийсэн ажил гүйлгээтэй холбоотой зардал юм. Сегментийн зардалд дараах зүйлс хамаарахгүй:

- (а) Сегментийн үйл ажиллагаа нь үндсэндээ санхүүгийн шинж төрөлтэй байхаас бусад тохиолдолд хүүний зардал, үүн дотроо бусад сегментүүдээс авсан урьдчилгаа буюу зээлийн хувьд гаргасан хүүний зардал;
- (б) Сегментийн үйл ажиллагаа нь үндсэндээ санхүүгийн шинж төрөлтэй байхаас бусад тохиолдолд хөрөнгө оруулалтын

борлуулалтаас үүссэн гарз эсвэл өрийн барагдуулалтаас үүссэн гарз;

- (в) Хараат байгууллага, хамтарсан үйлдвэр болон өмчийн аргын дагуу тайлагнадаг бусад хөрөнгө оруулалтын цэвэр алдагдал буюу гарзаас тухайн байгууллагад хамаарах хэсэг;
- (г) Орлогын татвар буюу орлогын татвартай адилтгах татвар төлөх үүргийг бүртгэн тайлагнах нягтлан бодох бүртгэлийн стандартуудын дагуу хүлээн зөвшөөрдөг орлогын татвар буюу орлогын татвартай адилтгах зардал; эсвэл
- (д) Ерөнхий удирдлагын зардал, төв оффисын зардал, түүнчлэн тухайн байгууллагын түвшинд гардаг бөгөөд бүхэлдээ уг байгууллагад хамаарах бусад зардал. Гэвч зарим үед сегментийн өмнөөс тухайн байгууллагын түвшинд зардал гардаг. Ийм зардал нь сегментийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой бөгөөд тухайн сегментэд шууд хамааруулах буюу ул үндэслэлтэй сууриар хуваарилж болох бол сегментийн зардал болно.

Үндсэндээ санхүүгийн шинж төрөлтэй сегментийн үйл ажиллагааны хувьд хүүний орлого ба хүүний зардлыг тухайн нэгтгэсэн буюу байгууллагын санхүүгийн тайланд цэвэр дүнгээр тусгадаг зөвхөн тийм тохиолдолд тэдгээрийг сегментийн тайлагналын зорилгоор нэг цэвэр дүн байдлаар тайлагнаж болно.

Сегментийн өр төлбөр гэдэг нь сегментийн үндсэн үйл ажиллагаанаас үүсдэг ба тухайн сегментэд шууд хамааруулж болох эсвэл ул үндэслэлтэй сууриар түүнд хуваарилж болох үйл ажиллагааны өр төлбөр юм.

Хэрэв сегментийн зардалд хүүний зардал хамаардаг бол түүний сегментийн өр төлбөрт холбогдох хүүтэй өр төлбөр хамаарна.

Орлогын татвар буюу орлогын татвартай адилтгах татвар төлөх үүргийг бүртгэн тайлагнах нягтлан бодох бүртгэлийн стандартуудын дагуу хүлээн зөвшөөрдөг орлогын татвар буюу орлогын татвартай адилтгах өр төлбөрүүд нь сегментийн өр төлбөрт хамаарахгүй.

Сегментийн орлого гэдэг нь төсвийн буюу адилтгах хуваарилалт, буцалтгүй тусламж, шилжүүлэг, торгууль, хураамж, гаднын худалдан авагчдад хийсэн борлуулалт эсвэл тухайн байгууллагын бусад сегментүүдтэй хийсэн ажил гүйлгээнээс үүссэн эсэхээс үл хамааран сегментэд шууд хамаарах ба ул үндэслэлтэй сууриар сегментэд хуваарилж болох уг байгууллагын орлогын холбогдох хэсэг зэрэг байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайланд тайлагнасан орлого юм. Сегментийн орлогод дараах зүйлс хамаарахгүй:

- (а) Сегментийн үйл ажиллагаа нь үндсэндээ санхүүгийн шинж төрөлтэй байхаас бусад тохиолдолд хүүний буюу ногдол

ашгийн орлого, үүн дотроо бусад сегментүүдэд олгосон урьдчилгаа буюу зээлийн хувьд олсон хүүний орлого; эсвэл

- (б) Сегментийн үйл ажиллагаа нь үндсэндээ санхүүгийн шинж төрөлтэй байхаас бусад тохиолдолд хөрөнгө оруулалтын борлуулалтаас үүссэн олз эсвэл өрийн барагдуулалтаас үүссэн олз.

**Нэгтгэсэн буюу байгууллагын нийт орлогод тусган оруулдаг зөвхөн тийм тохиолдолд хараат байгууллага, хамтарсан үйлдвэр болон өмчийн аргын дагуу тайлагнадаг бусад хөрөнгө оруулалтын цэвэр ашиг (алдагдал)-аас тухайн байгууллагад хамаарах хэсэг нь сегментийн орлогод хамаарна.**

### **Сегментэд хамаарах зүйлс**

28. Сегментийн орлого, сегментийн зардал, сегментийн хөрөнгө, сегментийн өр төлбөрийн тодорхойлолт нь сегментэд шууд хамаарах болон ул үндэслэлтэй сууриар сегментэд хуваарилж болох зүйлсийн дүнг агуулсан байдаг.
29. Байгууллага нь сегментэд шууд хамаарах буюу ул үндэслэлтэй байдлаар түүнд хуваарилж болох зүйлсийг тодорхойлох эхлэлийн цэг болгон өөрийн санхүүгийн дотоод тайлагналын системийг авч үздэг. Өөрөөр хэлбэл, дотоод тайлагналын зорилгоор ашигладаг сегментүүдийг нийтлэг зориулалттай санхүүгийн тайланд хэрэглэдэг буюу тийм зорилгоор ашиглах сегментүүдийн суурь үндэслэлийг бүрдүүлдэг тохиолдолд санхүүгийн дотоод тайлагналын зорилгоор сегментүүдийн хувьд тогтоосон дүнгүүд нь сегментийн орлого, сегментийн зардал, сегментийн хөрөнгө, сегментийн өр төлбөрийг хэмжих зорилгоор сегментүүдэд шууд хамаарах буюу ул үндэслэлтэй байдлаар тэдгээрт хуваарилж болно гэсэн урьдчилсан нөхцөлтэй байдаг.
30. Зарим тохиолдолд байгууллагын удирдлагад ойлгомжтой боловч санхүүгийн тайлангийн гаднын хэрэглэгчдийн хувьд субъектив, санамсаргүй тохиолдлын шинжтэй буюу ойлгоход төвөгтэй гэж санагдаж болох тийм сууриар орлого, зардал, хөрөнгө, өр төлбөрийг санхүүгийн дотоод тайлагналын зорилгоор сегментүүдэд хуваарилж болох юм. Ийм хуваарилалт нь энэ Стандартад заасан сегментийн орлого, сегментийн зардал, сегментийн хөрөнгө, сегментийн өр төлбөрийн тодорхойлолтод нийцсэн ул үндэслэлтэй суурийг орлохгүй юм. Харин эсрэгээр, ингэж хуваарилах ул үндэслэлтэй суурь оршин байлаа ч гэсэн байгууллага нь санхүүгийн дотоод тайлагналын зорилгоор орлого, зардал, хөрөнгө, өр төлбөрийн зарим зүйлсийг хуваарилахгүй байх сонголт хийж болно. Ийм зүйлсийг энэ Стандартад заасан сегментийн орлого, сегментийн зардал, сегментийн хөрөнгө, сегментийн өр төлбөрийн тодорхойлолтод нийцүүлэн хуваарилна.
31. Улсын секторын байгууллагууд нь (а) тодорхой бүлэг бараа, үйлчилгээг нийлүүлэх буюу зарим үйл ажиллагааг гүйцэтгэх өртөг зардал, ба (б)

тэдгээр үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай хөрөнгүүдийг ерөнхийдөө тодорхойлдог. Төлөвлөлт болон хяналтын зорилгын хувьд ийм мэдээлэл шаардлагатай байдаг. Гэвч ихэнх тохиолдолд засгийн газрын агентлагууд болон улсын секторын бусад байгууллагуудын үйл ажиллагааг “багц” төсвийн хуваарилалт эсвэл зардал буюу зарлагын гол ангиудын шинж төрлийг тусгасан “мөрийн зүйл” суурьт төсвийн хуваарилалтаар санхүүжүүлдэг. Ийм “багц” буюу “мөрийн зүйл”-ийн төсвийн хуваарилалт нь тодорхой үйлчилгээний төрөл, чиг үүргийн үйл ажиллагаа эсвэл газар зүйн бүс нутагтай хамааралгүй байж болох юм. Зарим тохиолдолд орлогыг сегментэд шууд хамааруулах буюу ул үндэслэлтэй сууриар хуваарилах боломжгүй байж болно. Үүнтэй адилаар, зарим хөрөнгө, зардал, өр төлбөр нь олон сегментэд хамаарах өргөн хүрээтэй үйлчилгээний нийлүүлэлтэнд дэмжлэг үзүүлдэг буюу тусдаа сегмент гэж тодорхойлоогүй ерөнхий удирдлагын үйл ажиллагаанд шууд хамаардаг учраас тэдгээрийг бие даасан сегментүүдэд шууд хамааруулах эсвэл ул үндэслэлтэй сууриар хуваарилах боломжгүй байж болно. Ийм хамаарахгүй буюу хуваарилаагүй орлого, зардал, хөрөнгө, өр төлбөрийг энэ Стандартын 64-р параграфтаар шаардсанчлан, сегментийн тодруулгыг тухайн байгууллагын нэгтгэн нийлүүлсэн орлоготой тохируулах үедээ хуваарилаагүй дүн гэж тайлагнана.

32. Засгийн газар болон түүний агентлагууд нь бараа, үйлчилгээ нийлүүлэх буюу бусад үйл ажиллагаа гүйцэтгэх гэрээ хэлцлийг хувийн хэвшлийн байгууллагуудтай байгуулж болох юм. Зарим улс оронд ийм хэлцэл нь нягтлан бодох бүртгэлийн өмчийн аргаар тайлагнах хамтарсан үйлдвэр буюу хараат байгууллага дахь хөрөнгө оруулалт хэлбэртэй байдаг. Ийм хэлбэртэй байх үед хэрэв өмчийн аргаар тайлагнасан ашиг (алдагдал)-ийг тухайн байгууллагын орлогод тусган оруулах ба сегментэд шууд хамааруулах буюу ул үндэслэлтэй сууриар хуваарилдаг бол сегментийн орлого нь тэрхүү өмчийн аргаар тайлагнасан ашиг (алдагдал)-аас түүнд хамаарах хэсгийг агуулсан байна.

### **Сегментийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зардал**

33. Сегментийн хөрөнгийн жишээнд тухайн сегментийн үндсэн үйл ажиллагаанд ашиглагдах эргэлтийн хөрөнгө; үндсэн хөрөнгө; санхүүгийн түрээсийн зүйл болох хөрөнгө; биет бус хөрөнгө хамаарна. Хэрэв тухайн элэгдэл буюу хорогдуулгын зардлыг сегментийн зардалд оруулдаг бол уг холбогдох хөрөнгийг мөн сегментийн хөрөнгөнд хамруулна. Байгууллагын буюу төв оффисын ерөнхий зорилгод ашигладаг хөрөнгүүд нь сегментийн хөрөнгөнд хамаарахгүй. Тухайлбал;
- (а) Боловсролын хэлтсийн төв захиргаа удирдлагын болон бодлогын хөгжлийн нэгжийн оффисыг анхан, дунд, ахисан түвшний боловсролын үйлчилгээ үзүүлдэг сегментүүдэд хамруулан тусгадаггүй; эсвэл
  - (б) Нийт засгийн газрын түвшинд тайлагнадаг тохиолдолд боловсрол, эрүүл мэнд, батлан хамгаалах гэх мэт гол чиг үүргийн үйл

## СЕГМЕНТИЙН ТАЙЛАГНАЛ

ажиллагаануудыг тусгадаг сегментүүдэд парламентын болон бусад нийтийн хурлын барилгыг хамруулан тусгахгүй.

Хэрэв хуваарилалтын ул үндэслэлтэй суурь оршин байвал хоёр буюу хэд хэдэн сегментүүдийн хамтран ашигладаг үйл ажиллагааны хөрөнгүүд нь сегментийн хөрөнгөнд хамаардаг.

34. Засгийн газрын болон бусад байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлан нь улсын секторын нэгдлээр олж эзэмшсэн ба худалдан авалтын гүүдвилл үүсгэдэг үйл ажиллагаануудыг өөртөө агуулдаг байж болох юм (үйл ажиллагааны худалдан авалтыг тайлагнах талаархи заавар удирдамжийг УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-д тусгасан). Ийм тохиолдолд сегментэд шууд хамаарах буюу ул үндэслэлтэй сууриар түүнд хуваарилж болох гүүдвилл нь сегментийн хөрөнгөнд, харин гүүдвиллийн холбогдох хорогдуулга нь сегментийн зардалд хамаарна.
35. Сегментийн өр төлбөрийн жишээнд худалдааны болон бусад өглөг, хуримтлагдсан өглөг, хэсэгчилсэн татаастайгаар ирээдүйд бараа, үйлчилгээ нийлүүлэхэд зориулан тухайн нийгмийн гишүүдээс авсан урьдчилгаа, байгууллагын аливаа худалдаа арилжааны үйл ажиллагаанаас үүссэн бүтээгдэхүүний баталгааны өглөг ба бараа, үйлчилгээний нийлүүлэлттэй холбоотой бусад нэхэмжлэлүүд хамаарна. Зээл, санхүүгийн түрээсийн зүйл болох хөрөнгөтэй холбоотой өр төлбөр, үндсэн үйл ажиллагааны зорилгоор бус, харин санхүүжилттэй холбоотой үүссэн бусад өр төлбөр нь сегментийн өр төлбөрт хамаарахгүй. Хэрэв хүүний зардлыг сегментийн зардалд оруулдаг бол холбогдох хүүтэй өр төлбөр нь сегментийн өр төлбөрт хамаарна.
36. Үйл ажиллагаа нь үндсэндээ санхүүгийн шинж төрөлтэй биш сегментийн орлого, зардалд санхүүгийн орлого, зардлыг оруулдаггүй учраас зээл болон адилтгах өр төлбөр нь сегментийн өр төлбөрт хамаарахгүй. Түүнчлэн, өрийг ихэвчлэн төв оффисын түвшинд гаргадаг бөгөөд нийт байгууллагын буюу нийт засгийн газрын түвшний зээлийн төвлөрсөн эрхээр өр үүсгэх зөвшөөрөл олгодог учраас хүүтэй өр төлбөрийг сегментэд шууд хамааруулах буюу ул үндэслэлтэйгээр хуваарилах ихэвчлэн боломжгүй байдаг. Гэвч нийт засгийн газрын түвшинд ангилахтай адилаар тухайн байгууллагын санхүүжилтийн үйл ажиллагааг тусдаа сегмент гэж тодорхойлдог бол уг “санхүүгийн” сегментийн зардалд хүүний зардал, харин тэрхүү сегментийн өр төлбөрт холбогдох хүүтэй өр төлбөр хамаарна.
37. Улсын секторын нэгдлээр олж эзэмшсэн үйл ажиллагааны тухайн тодорхойлогдох хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэд тохируулга хийхийг УСНББОУС 40-өөр шаардаж болох юм. Улсын секторын нэгдлээр олж эзэмшсэн үйл ажиллагааны тухайн тодорхойлогдох сегментийн хөрөнгө, өр төлбөрийн өмнөх дансны үнийн аливаа тохируулгыг зөвхөн нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх зорилгоор хийдэг бөгөөд хяналт тавигч байгууллагын тусдаа эсвэл хяналтанд буй байгууллагын бие даасан санхүүгийн тайлангийн аль нэгэнд түүнийг бүртгэдэггүй боловч тэдгээр залруулгыг тухайн сегментийн хөрөнгө, өр төлбөрийн хэмжилтэнд тусган



оруулна. Үүнтэй адилаар, үндсэн хөрөнгийг түүний худалдан авалтын дараа УСНББОУС 17, *Үндсэн Хөрөнгө*-д заасан дахин үнэлгээний загварын дагуу дахин үнэлсэн бол тэрхүү дахин үнэлгээг сегментийн хөрөнгийн хэмжилтэнд тусгана.

38. Зарим улс оронд засгийн газар буюу засгийн газрын байгууллага нь орлогын татвар буюу орлогын татвартай адилтгах татвар төлдөг тийм улсын секторын худалдаа арилжааны байгууллагыг хянадаг байж болох юм. Эдгээр байгууллагууд нь орлогын татвар буюу орлогын татвартай адилтгах татварын нягтлан бодох бүртгэлийн хандлагыг тодорхойлдог, НББОУС 12, *Орлогын Албан Татвар* гэх мэт нягтлан бодох бүртгэлийн стандартуудыг мөрдөх шаардлагатай байж болно. Ийм стандартууд нь тухайн тайлант үед хүлээн зөвшөөрсөн ба ирээдүйн тайлант үеүдэд нөхөн олгогдох эсвэл буцаан төлөгдөх орлогын татварын зардал буюу орлогын татвартай адилтгах зардлын хувьд орлогын татварын хөрөнгө болон өр төлбөр хүлээн зөвшөөрөхийг шаардаж болох юм. Эдгээр хөрөнгө, өр төлбөр нь бүхэлдээ тухайн байгууллагын нийт үйл ажиллагаа болон уг байгууллагад хамаарах татварын зохицуулалтын үр дүн байдлаар үүсдэг учраас тэдгээрийг сегментийн хөрөнгө буюу сегментийн өр төлбөрт хамруулан оруулахгүй. Гэвч татварын эрх бүхий байгууллагын хянадаг, татварын орлогын авлагыг илэрхийлэх хөрөнгүүдийг тухайн сегментэд шууд хамруулах буюу найдвартай<sup>1</sup> сууриар хуваарилах боломжтой бол түүнийг тэрхүү эрх бүхий байгууллагын сегментийн хөрөнгөнд тусган оруулна.
39. Өртгийн хуваарилалтын талаархи зарим заавар удирдамжийг бусад УСНББОУС-уудаас үзэж болно. Жишээлбэл; УСНББОУС 12, *Бараа Материал* нь өртгийг бараа материалд хамааруулан шингээх ба хуваарилах заавар удирдамжаар хангадаг. Харин УСНББОУС 11, *Барилгын Гэрээ* нь өртгийг гэрээт ажилд хамааруулан шингээх ба хуваарилах заавар удирдамжаар хангадаг. Ийм заавар удирдамж нь өртгийг сегментүүдэд хамааруулан шингээх ба хуваарилахад ач холбогдолтой байж болох юм.
40. УСНББОУС 2, *Мөнгөн Гүйлгээний Тайлан* нь банкны овердрафтыг мөнгөн хөрөнгийн бүрэлдэхүүнд оруулах эсвэл зээл байдлаар тайлагнах эсэх заавар удирдамжаар хангадаг.
41. Нийт засгийн газрын болон хяналт тавигч бусад зарим байгууллагуудын санхүүгийн тайлан нь хэлтэс, агентлаг, улсын секторын худалдаа арилжааны байгууллага гэх мэт олон тооны тусдаа байгууллагуудыг нэгтгэхийг шаарддаг. Ийм нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ, хяналтанд буй байгууллагуудын хоорондох ажил гүйлгээ болон

<sup>1</sup> Найдвартай мэдээлэл нь материаллаг алдаа ба туйлшралаас ангид байх бөгөөд өөрийн илэрхийлэхээр зориулагдсан буюу илэрхийлнэ гэж ул үндэслэлтэйгээр хүлээж болох зүйлсийг үнэн зөв илэрхийлэхдээ хэрэглэгчдээс хамаардаг байж болох юм. Найдвартай байдлын тайлбарын талаархи шилжилтийн арга хандлагыг УСНББОУС 1-ийн ДҮ16-р параграфт авч хэлэлцсэн.

үлдэгдлүүдийг УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*-гийн дагуу хааж, устгана. Гэвч эдийн засгийн нэгдмэл байгууллагын дотоод үлдэгдэл ба ажил гүйлгээ нь нэг сегментийн хүрээн дэх байгууллагуудын хооронд үүссэнээс бусад тохиолдолд тэрхүү эдийн засгийн нэгдмэл байгууллагын доторх байгууллагуудын хоорондох үлдэгдлүүд болон ажил гүйлгээг нэгтгэлийн процессын нэг хэсэг байдлаар устгаж хаахын өмнө сегментийн орлого, сегментийн зардал, сегментийн хөрөнгө, сегментийн өр төлбөрийг тодорхойлдог.

42. Бүхэлдээ байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж, толилуулахад ашигладаг нягтлан бодох бүртгэлийн бодлого нь мөн тухайн сегментийн нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого байх тохиолдолд тэрхүү бодлогоос гадна, сегмент хоорондын шилжүүлгийн үнэ тогтоох арга ба орлого, зардлыг сегментүүдэд хуваарилах суурь гэх мэт сегментийн тайлагналд тусгайлан хамаарах бодлого нь уг сегментийн бодлогод хамаарна.

### **Сегментийн нягтлан бодох бүртгэлийн бодлого**

43. **Нэгтгэсэн групп буюу байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж, толилуулахад мөрддөг нягтлан бодох бүртгэлийн бодлогод нийцүүлэн сегментийн мэдээллийг бэлтгэнэ.**
44. Нэгтгэсэн буюу байгууллагын хэмжээний санхүүгийн тайланг бэлтгэхдээ ашиглахаар уг байгууллагын удирдах зөвлөл ба дээд түвшний менежерийн сонгосон нягтлан бодох бүртгэлийн бодлого нь гаднын тайлагналын зорилгын хувьд хамгийн тохиромжтой гэж тэдгээр удирдах зөвлөл болон удирдлагын үзсэн тийм бодлого байдаг. Сегментийн мэдээллийн зорилго нь бүхэлдээ байгууллагын талаар илүү сайн ойлголттой болох ба илүү их мэдээлэл бүхий шүүн тунгаалт хийхэд санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд туслах явдал учраас энэхүү Стандарт нь нэгтгэсэн буюу байгууллагын хэмжээний санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдах зөвлөл болон удирдлагын сонгосон тэрхүү нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тухайн сегментийн мэдээлэл бэлтгэхэд ашиглахыг шаарддаг. Гэхдээ сегментүүд нь тайлагнагч тусдаа байгууллагууд байсан мэтээр уг нэгтгэсэн буюу байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тэдгээр сегментүүдэд хэрэглэнэ гэсэн үг биш юм. Харин тухайн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг нийт байгууллагын түвшинд мөрдөхдөө хийсэн нарийвчилсан тооцооллыг хэрэв ул үндэслэтэй суурь байгаа бол сегментүүдэд хамааруулан хуваарилж болох юм. Тухайлбал; ажиллагчдын амралтын цалин, тэтгэмжийн тооцооллыг ихэвчлэн байгууллагын түвшинд хийдэг боловч уг байгууллагын хэмжээний дүнг сегментүүдийн цалин хөлс болон хүн ам зүйн мэдээнд үндэслэн тэдгээр сегментүүдэд хуваарилж болно.
45. 42-р параграфт дурдсанчлан, сегмент хоорондын үнэ тогтоолт гэх мэт зөвхөн байгууллагын хэмжээний асуудлуудтай холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хөгжүүлэн боловсруулах шаардлагатай байж болох юм. Санхүүгийн тайланг ойлгоход зайлшгүй шаардлагатай нягтлан бодох

бүртгэлийн бодлогын тодруулга хийхийг УСНББОУС 1-ээр шаардсан байдаг. Түүний шаардлагуудад нийцүүлэн сегментийн тусгай бодлогуудыг тодруулах шаардлагатай байж болно.

46. Дараах тохиолдолд энэ Стандарт нь нэгтгэсэн буюу байгууллагын санхүүгийн тайланд мөрддөг нягтлан бодох бүртгэлийн бодлогоос өөр сууриар сегментийн нэмэлт мэдээллийн тодруулга бэлтгэхийг зөвшөөрдөг:
- (a) Тухайн мэдээлэл нь гүйцэтгэлийн үнэлгээ болон шийдвэр гаргах зорилгод хамааралтай байх; ба
  - (б) Тухайн нэмэлт мэдээллийн хэмжилтийн суурийг тодорхой ойлгомжтой илэрхийлсэн байх.

### **Хамтын хөрөнгө**

47. **Хоёр буюу хэд хэдэн сегментүүдийн хамтран ашигладаг хөрөнгүүдийн холбогдох орлого, зардлыг тэдгээр сегментүүдэд мөн хуваарилдаг бол, зөвхөн тийм тохиолдолд тухайн хөрөнгүүдийг сегментүүдэд хуваарилна.**
48. Хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын зүйлсийг сегментүүдэд хуваарилах арга зам нь тэдгээр зүйлсийн шинж төрөл, сегментийн эрхлэн явуулдаг үйл ажиллагаа, тухайн сегментийн харьцангуй бие даасан байдал зэрэг хүчин зүйлсээс хамаардаг. Бүх байгууллагууд мөрдөх хэрэгтэй гэсэн хуваарилалтын ганц суурийг тусгайлан заах боломжгүй бөгөөд тохиромжгүй юм. Мөн ийм хуваарилалт хийх цорын ганц суурь нь санамсаргүй тохиолдлын шинжтэй эсвэл ойлгоход амаргүй бол хоёр буюу хэд хэдэн сегментэд хамтдаа хамаарах тухайн байгууллагын хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын зүйлсийг хуваарилахыг албадан шаардах нь тохиромжгүй байдаг. Нийт сегментийн орлого, сегментийн зардал, сегментийн хөрөнгө, сегментийн өр төлбөрийг тодорхойлох үйл ажиллагаа нь харилцан уялдаатай байх тохиолдолд түүний үр дүнд хийгдэх хуваарилалт нь тууштай байдаг. Иймээс хамтран ашигладаг хөрөнгүүдийн холбогдох орлого, зардлыг мөн сегментүүдэд хуваарилдаг бол, зөвхөн тохиолдолд тэдгээр хөрөнгийг сегментүүдэд хуваарилна. Жишээлбэл; холбогдох элэгдэл буюу хорогдуулгыг сегментийн зардлыг хэмжихдээ тусган оруулдаг бол, зөвхөн тийм тохиолдолд уг хөрөнгийг сегментийн хөрөнгөнд хамааруулна.

### **Шинээр тодорхойлсон сегмент**

49. **Сегментийг тухайн тайлант үед анх удаа сегмент гэж тодорхойлсон бол уг шинээр тайлагнасан сегментийг тусдаа сегмент гэж тусгахын тулд зэрэгүүлэлтийн зорилгоор толилуулсан сегментийн өмнөх тайлант үеийн мэдээг практик боломжгүй байхаас бусад тохиолдолд дахин илэрхийлнэ.**

50. Шинэ сегментүүдийг янз бүрийн тохиолдолд санхүүгийн тайланд тайлагнаж болно. Жишээлбэл; байгууллага нь үйлчилгээний сегментийн бүтцээс газар зүйн сегментийн бүтэц болгон өөрийн дотоод тайлагналын бүтцийг өөрчилж болох бөгөөд удирдлага нь гадаад тайлагналын зорилгоор сегментийн ийм бүтцийг бас мөрдөх нь тохиромжтой гэж үзэж болох юм. Байгууллага нь мөн шинэ буюу нэмэлт томоохон үйл ажиллагааг эрхлэн явуулах эсвэл гаднын талуудад үйлчилгээ үзүүлэх дотоод дэмжих үйлчилгээ байдлаар өмнө нь ажиллаж байсан үйл ажиллагааны хэмжээг нэмэгдүүлж болох юм. Ийм тохиолдолд ерөнхий зориулалттай санхүүгийн тайланд уг шинэ сегментүүдийг анх удаа тайлагнаж болох юм. Ингэж тайлагнах тохиолдолд практик боломжтой хэмжээгээр сегментийн одоогийн бүтцийг тусгахын тулд өмнөх тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээг дахин илэрхийлэхийг энэхүү Стандартаар шаарддаг.

## Тодруулга

51. **52-75-р параграф дахь тодруулгын шаардлагуудыг сегмент нэг бүрд мөрдөнө.**
52. **Байгууллага нь сегмент нэг бүрийн хувьд сегментийн орлого ба сегментийн зардлыг тодруулна. Төсвийн хуваарилалт буюу адилтгах хуваарилалтаас үүссэн сегментийн орлого, гаднын бусад эх үүсвэрээс олсон сегментийн орлого, бусад сегментүүдтэй хийсэн ажил гүйлгээнээс үүссэн сегментийн орлогыг тус тусад нь тайлагнана.**
53. **Байгууллага нь сегмент нэг бүрийн хувьд сегментийн хөрөнгүүдийн нийт дансны үнийг тодруулна.**
54. **Байгууллага нь сегмент нэг бүрийн хувьд сегментийн өр төлбөрүүдийн нийт дансны үнийг тодруулна.**
55. **Байгууллага нь нэгээс олон тайлант үеийн туршид ашиглахаар хүлээгдэж буй сегментийн хөрөнгүүдийг олж эзэмшихийн тулд тухайн тайлант үеийн туршид гаргасан нийт өртөг зардлыг сегмент нэг бүрийн хувьд тодруулна.**
56. Сегмент нэг бүрийн тухайн тайлант үеийн үр дүнг тайлбарлахад тодруулга нь хамааралтай байх тийм хэмжээ, төрөл, нөлөөлөл бүхий сегментийн орлого ба сегментийн зардлын аливаа зүйлсийн шинж төрөл болон дүнг байгууллага нь тодруулахыг дэмжих боловч түүнээс заавал шаардахгүй.
57. Орлого буюу зардлын зүйлс нь материаллаг байх тохиолдолд тийм зүйлсийн шинж төрөл ба дүнг тусад нь тодруулахыг УСНББОУС 1-ээр шаарддаг. УСНББОУС 1 нь ийм зүйлсийн олон жишээг тодорхойлсон. Үүнд: бараа материал ба үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууруулалт; бүтцийн өөрчлөлтийн зардал; үндсэн хөрөнгийн данснаас хасалт;

## СЕГМЕНТИЙН ТАЙЛАГНАЛ

хувьчлал ба урт хугацаат хөрөнгө оруулалтын бусад данснаас хасалт; зогсоосон үйл ажиллагаа; зарга маргааны шийдвэрлэлт; нөөц сангийн буцаалт хамаарна. 56-р параграф нь ийм аливаа зүйлсийн ангиллыг өөрчлөх эсвэл ийм зүйлсийн хэмжилтийг өөрчлөх зорилгогүй болно. Харин уг параграфт заасан тодруулга нь ийм зүйлсийн ач холбогдлыг үнэлэх түвшинг тодруулгын зорилгоор тухайн байгууллагын түвшнээс сегментийн түвшин болгон өөрчилдөг.

58. Энэ Стандарт нь сегментийн үр дүнг тодруулахыг шаарддаггүй. Гэвч сегментийн үр дүнг тооцоолж, тодруулдаг бол энэ нь санхүүгийн зардлыг тусган агуулаагүй тийм үйл ажиллагааны үр дүн байна.
59. Байгууллага нь УСНББОУС 2-ын шаардлагуудын дагуу сегментийн мөнгөн гүйлгээг тодруулахыг дэмжих боловч түүнээс заавал шаарддаггүй. УСНББОУС 2 нь үндсэн үйл ажиллагааны, хөрөнгийн оруулалтын, санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг тус тусад нь тайлагнах тийм мөнгөн гүйлгээний тайлан толилуулахыг байгууллагаас шаарддаг. Мөн энэ нь зарим мөнгөн гүйлгээний талаархи мэдээллийг тодруулахыг шаарддаг. Сегмент нэг бүрийн талаархи мөнгөн гүйлгээний мэдээллийн тодруулга нь тухайн байгууллагын ерөнхий санхүүгийн байдал, төлбөрийн чадвар болон мөнгөн гүйлгээг ойлгоход ач холбогдолтой байдаг.
60. УСНББОУС 2-ын дагуу сегментийн мөнгөн гүйлгээг тодруулдаггүй байгууллага нь тайлагнах сегмент нэг бүрийн хувьд дараах зүйлсийг тодруулахыг дэмжих боловч түүнээс заавал шаардахгүй:
- (а) Сегментийн хөрөнгүүдийн элэгдэл ба хорогдуулгын сегментийн зардал;
  - (б) Мөнгөн бус бусад мэдэгдэхүйц зардал; ба
  - (в) Сегментийн орлогод тусган оруулдаг мөнгөн бус мэдэгдэхүйц орлого.

Энэ нь сегментийн тухайн тайлант үеийн үйл ажиллагааны хувьд мөнгөний гол эх үүсвэр ба ашиглалтыг тодорхойлох боломжийг хэрэглэгчдэд олгодог.

61. **Хараат байгууллага, хамтарсан үйлдвэр буюу өмчийн аргаар тайлагнадаг бусад хөрөнгө оруулалтын бараг бүх үйл ажиллагаа нь тухайн нэг сегментийн хүрээнд хамаардаг бол байгууллага нь тэдгээр хараат байгууллага, хамтарсан үйлдвэр буюу бусад хөрөнгө оруулалтын цэвэр ашиг (алдагдал) дахь өөрийн хувь хэсгийн нэгтгэн нийлүүлсэн дүнг сегмент тус бүрээр тодруулна.**
62. Нэгтгэн нийлүүлсэн ганц дүнг 61-р параграфын шаардлагуудын дагуу тодруулахаас гадна түүний үйл ажиллагаа нь тухайн сегментийн хүрээнд бараг бүгд хамаарах эсэхийг тодорхойлохын тулд хараат байгууллага, хамтарсан үйлдвэр буюу өмчийн аргаар тайлагнадаг бусад хөрөнгө оруулалт нэг бүрийг тусад нь үнэлнэ.

63. Хараат байгууллага, хамтарсан үйлдвэр буюу өмчийн аргаар тайлагнадаг бусад хөрөнгө оруулалтын цэвэр ашиг (алдагдал) дахь тухайн байгууллагын хувь хэсгийн нэгтгэн нийлүүлсэн дүнг сегментээр тодруулдаг бол тэдгээр хараат байгууллага болон хамтарсан үйлдвэр дэх нэгтгэн нийлүүлсэн хөрөнгө оруулалтыг мөн сегментээр тодруулна.
64. Байгууллага нь сегментүүдийн хувьд тодруулсан мэдээлэл ба нэгтгэсэн буюу байгууллагын санхүүгийн тайланд тусгасан, нэгтгэн нийлүүлсэн мэдээллийн хоорондох тохируулгын тайланг толилуулна. Тохируулгын тайланг толилуулахдаа, сегментийн орлогыг уг байгууллагын гадны эх үүсвэрээс олсон орлоготой тохируулна (үүн дотроо, тухайн байгууллагын гаднын эх үүсвэрээс олсон бөгөөд аливаа сегментийн орлогод тусган оруулаагүй дүнгийн тодруулга); сегментийн зардлыг уг байгууллагын зардлын зэрэгцүүлэгдэх хэмжээтэй тохируулна; сегментийн хөрөнгийг байгууллагын хөрөнгөтэй тохируулна; сегментийн өр төлбөрийг байгууллагын өр төлбөртэй тохируулна.

#### Сегментийн нэмэлт мэдээлэл

65. Өмнө дурдсанчлан, сегментүүд нь ихэвчлэн тухайн байгууллагын нийлүүлдэг гол бараа, үйлчилгээ, түүний эрхлэн явуулдаг хөтөлбөр, хийж гүйцэтгэдэг үйл ажиллагаанд ихэвчлэн үндэслэнэ гэж төсөөлдөг. Яагаад гэвэл, эдгээр сегментүүдийн талаархи мэдээлэл нь зорилтууддаа хүрэхийн тулд хийсэн тухайн байгууллагын гүйцэтгэлийн талаархи холбогдох мэдээллээр хэрэглэгчдийг хангаж, өөрийн тайлагналын үүрэг хариуцлагыг биелүүлэх боломжийг уг байгууллагад олгодог. Гэвч зарим байгууллагын хувьд, газар зүйн буюу бусад суурь нь үйлчилгээг үзүүлэх ба тухайн байгууллагын дотор нөөцийг хуваарилах суурийг хамгийн сайн тусгаж болох бөгөөд иймээс түүнийг санхүүгийн тайлагналын зорилгоор хэрэглэнэ.
66. Үйлчилгээний сегмент болон газар зүйн сегментийн аль алины талаархи хамгийн наад захын мэдээллийн тодруулга нь тайлагналын хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгын хувьд хэрэглэгчдэд ач холбогдолтой байх магадлалтай гэсэн үзэл бодлыг энэ Стандартад баримталдаг. Иймээс хэрэв байгууллага нь сегментийн мэдээллийг:
- (а) өөрийн нийлүүлдэг гол бараа үйлчилгээ, эрхлэн явуулдаг хөтөлбөр, хийж гүйцэтгэдэг үйл ажиллагаа буюу бусад үйлчилгээний сегментүүдэд үндэслэн тайлагнадаг бол тухайн байгууллага нь удирдах зөвлөл болон дээд түвшний менежертээ дотооддоо тайлагнадаг газар зүйн сегмент тус бүрийн хувьд дараах зүйлсийг тайлагнахыг мөн сайшаан дэмжинэ:
- (i) Сегментийн зардал;
- (ii) Сегментийн хөрөнгийн нийт дансны үнэ; ба

## СЕГМЕНТИЙН ТАЙЛАГНАЛ

- (iii) Нэгээс олон тайлант үеийн туршид ашиглагдахаар хүлээгдэж буй сегментийн хөрөнгүүдийг (үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгийг) худалдан авахын тулд тухайн тайлант үед гаргасан нийт зарлага; ба
- (б) (а)-д дурдаагүй газар зүйн сегментүүд буюу бусад суурьд үндэслэн тайлагнадаг бол тухайн байгууллага нь удирдах зөвлөл болон дээд түвшний менежертээ дотооддоо тайлагнадаг үйлчилгээний гол сегмент тус бүрийн хувьд сегментийн дараах мэдээллийг тайлагнахыг мөн сайшаан дэмжинэ:
  - (i) Сегментийн зардал;
  - (ii) Сегментийн хөрөнгийн нийт дансны үнэ; ба
  - (iii) Нэгээс олон тайлант үеийн туршид ашиглагдахаар хүлээгдэж буй сегментийн хөрөнгүүдийг (үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгийг) худалдан авахын тулд тухайн тайлант үед гаргасан нийт зарлага.

### Тодруулгын бусад асуудлууд

67. **Бусад сегментүүдтэй хийсэн ажил гүйлгээнээс үүссэн сегментийн орлогыг хэмжиж тайлагнах үед сегмент хоорондын шилжүүлгийг тэдгээрийн гарч тохиолдсон сууриар хэмжинэ. Сегмент хоорондын шилжүүлгийн үнэ тогтоох суурь ба түүний аливаа өөрчлөлтийг санхүүгийн тайланд тодруулна.**
68. **Сегментийн мэдээлэлд материаллаг нөлөөтэй ба сегментийн тайлагналд мөрддөг нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг тодруулах бөгөөд зэрэгцүүлэх зорилгоор толилуулсан өмнөх тайлант үеийн сегментийн мэдээллийг практик боломжгүй байхаас бусад тохиолдолд дахин илэрхийлнэ. Өөрчлөлтийн шинж төрлийн талаархи тайлбар тодорхойлолт, өөрчлөлтийн шалтгаан, уг зэрэгцүүлэгдэх мэдээллийг дахин илэрхийлсэн эсвэл ингэх практик боломжгүй байсан тухай тайлбар, хэрэв ул үндэслэлтэйгээр тодорхойлох боломжтой бол тэрхүү өөрчлөлтийн санхүүгийн үр нөлөө зэрэг нь ийм тодруулгад хамаарна. Байгууллага нь сегментийн тодорхойлолтоо өөрчилсөн бөгөөд практик боломжгүйн улмаас өмнөх тайлант үеийн сегментийн мэдээллийг уг шинэ сууриар дахин илэрхийлээгүй бол зэрэгцүүлэлтийн зорилгоор тэрхүү байгууллага нь өөрийн сегментүүдийн тодорхойлолтыг өөрчилсөн тухайн жилд сегментийн хуучин ба шинэ суурийн аль алианаар сегментийн мэдээг тайлагнана.**
69. Байгууллагын мөрддөг нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-ны дагуу тайлагнана. (а) Өөрчлөлтийг УСНББОУС-аар шаардсан, эсвэл (б) өөрчлөлт нь тухайн байгууллагын санхүүгийн тайланд ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлын талаар илүү үнэн зөв илэрхийлэл болон илүү хамааралтай

## СЕГМЕНТИЙН ТАЙЛАГНАЛ

мэдээллийг бий болгох зөвхөн тийм тохиолдолд УСНББОУС 3 нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт хийхийг шаарддаг.

70. Байгууллагын түвшинд мөрддөг бөгөөд сегментийн мэдээлэлд нөлөө үзүүлэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг УСНББОУС 3-ын дагуу тайлагнана. Шинэ УСНББОУС нь өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд УСНББОУС 3 нь дараах зүйлсийг шаардана:
- (а) Тухайн өөрчлөлтийн тодорхой нэг тайлант үед үзүүлэх үр нөлөөг эсвэл нийт хуримтлагдсан үр нөлөөг тодорхойлох практик боломжгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг буцаах горимоор мөрдөж, уг өмнөх тайлант үеийн мэдээллийг дахин илэрхийлнэ;
  - (б) Толилуулсан бүх тайлант үеүдийн хувьд буцаах горимоор мөрдөх практик боломжгүй бол практик боломжтой хамгийн эхний өмнөх тайлант үеэс эхлэн уг нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг буцаах горимоор мөрдөнө; ба
  - (в) Нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг мөрдөхийн нийт хуримтлагдсан үр нөлөөг тухайн тайлант үеийн эхний байдлаар тодорхойлох практик боломжгүй тохиолдолд практик боломжтой хамгийн эхний өмнөх тайлант үеэс эхлэн уг нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг гүйцээх горимоор мөрдөнө.
71. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын зарим өөрчлөлт нь сегментийн тайлагналд тусгайлан хамаардаг. Жишээлбэл; сегментийн тодорхойлолтын өөрчлөлт, орлого ба зардлыг сегментүүдэд хуваарилах суурийн өөрчлөлт. Ийм өөрчлөлт нь тухайн тайлагнасан сегментийн мэдээлэлд мэдэгдэхүйц нөлөөтэй боловч уг байгууллагын хувьд тайлагнасан нийт санхүүгийн мэдээллийг өөрчлөхгүй. Өөрчлөлтийг ойлгож, түүний хандлагыг үнэлэх боломжийг хэрэглэгчдэд олгохын тулд уг нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг тусгах үүднээс тухайн санхүүгийн тайланд зэрэгцүүлэлтийн зорилгоор харуулсан өмнөх тайлант үеийн сегментийн мэдээллийг хэрэв практик боломжтой бол дахин илэрхийлнэ.
72. Сегмент хоорондын шилжүүлгийн үнийг тогтоохдоо тухайн байгууллагын бодитойгоор ашигладаг суурьт үндэслэн сегментийн тайлагналын зорилгоор тэдгээр сегмент хоорондын шилжүүлгийг хэмжинэ гэж 67-р параграфт заасан. Хэрэв байгууллага нь сегмент хоорондын шилжүүлгийн үнийг тогтоохдоо өөрийн бодитойгоор ашигладаг аргаа өөрчилсөн бол энэ нь 68-р параграфын дагуу өмнөх тайлант үеийн сегментийн мэдээг нь дахин илэрхийлэх тийм нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт болохгүй. Харин тухайн өөрчлөлтийн хувьд тодруулга хийхийг 67-р параграфтаар шаардсан байдаг.
73. **Хэрэв санхүүгийн тайланд буюу жилийн тайлан илтгэлийн аль нэг хэсэгт өөр бусад байдлаар тодруулаагүй бол байгууллага нь дараах зүйлсийг тусган илэрхийлнэ:**



- (a) Тайлагнасан үйлчилгээний сегмент нэг бүрд тусган оруулсан бараа, үйлчилгээний төрөл;
- (б) Тайлагнасан газар зүйн сегмент нэг бүрийн бүтэц бүрэлдэхүүн; ба
- (в) Сегментийн үйлчилгээний буюу газар зүйн суурийн аль алиныг хэрэглэдэггүй бол тухайн сегментийн болон түүнд хамаарах үйл ажиллагаануудын шинж төрөл.

#### **Сегментийн үйл ажиллагааны зорилтууд**

- 74. Хэрэв санхүүгийн тайланд буюу жилийн тайлан илтгэлийн аль нэг хэсэгт өөр бусад байдлаар тодруулаагүй бол байгууллага нь тухайн тайлант үеийн эхэнд сегмент нэг бүрийн хувьд тогтоосон үйл ажиллагааны ерөнхий зорилтуудыг тодруулах ба тэдгээр зорилтуудын биеллэлтийн хэмжээний талаар санал зөвлөмжөө илэрхийлэхийг сайшаан дэмжинэ.
- 75. Өөрийн үйлчилгээний нийлүүлэлтийн зорилтуудад хүрэх тухайн байгууллагын гүйцэтгэлийг үнэлэх боломжийг хэрэглэгчдэд олгохын тулд тэдгээр зорилтуудыг хэрэглэгчдэд хүргэн танилцуулах шаардлагатай байдаг. Сегмент нэг бүрийн бүтэц бүрэлдэхүүн, сегментүүдийн үйлчилгээний нийлүүлэлтийн зорилтууд болон тэдгээр зорилтуудын биелэлтийн хэмжээний талаархи мэдээллийн тодруулга нь ийм үнэлгээнд туслалцаа үзүүлдэг. Ийм мэдээлэл нь мөн өөрийн тайлагналын үүрэг хариуцлагыг илүү их сайн биелүүлэх боломжийг тухайн байгууллагад олгодог. Удирдах зөвлөл буюу дээд түвшний менежерт танилцуулах тайлангийн нэг хэсэг байдлаар ийм мэдээллийг ихэнх тохиолдолд жилийн тайлан илтгэлд тусган оруулдаг. Ийм тохиолдолд уг мэдээллийг санхүүгийн тайланд тодруулах шаардлагагүй байдаг.

#### **Хүчин төгөлдөр болох хугацаа**

- 76. Байгууллага нь энэхүү Стандартыг 2003 оны 7 дугаар сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2003 оны 7 дугаар сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 76А. 2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх-ийн үр дүнд 77-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан*. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед УСНББОУС 33-ыг мөрдсөн бол уг нэмэлт өөрчлөлтийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.

- 76Б. 2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 37, *Хамтын Хэлэлцээр*-ийн үр дүнд 27, 32-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь УСНББОУС 37-г мөрдсөн үеэс эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг дагаж мөрдөнө.
- 76В. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд*-аар 69-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 76Г. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 2, 3-р параграфуудыг хасаж, 16, 24, 38, 41-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 76Д. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийн үр дүнд 34, 37-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.
77. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

## Дүгнэлтийн Үндэслэл

Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 18-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

**2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУС3-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 18-д хийсэн хянан засварлалт**

ДҮ1. УСНББОУС3 нь 2016 оны 4 дүгээр сард УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (а) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р* параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

## Хэрэгжүүлэх заавар удирдамж

*Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 18-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### Шаардлагатай тодруулгын тойм

[᠑᠕ᠰ] нь энэ Стандартын хх-р параграф гэдгийг илэрхийлнэ.

#### *Тодруулга*

Сегментээр харуулсан нийт зардал [᠑52]

Сегментээр харуулсан нийт орлого [᠑52]

Сегментээр харуулсан, төсвийн хуваарилалт буюу адилтгах хуваарилалтаас үүссэн орлого [᠑52]

Сегментээр харуулсан, гаднын (төсвийн хуваарилалт буюу адилтгах хуваарилалтаас бусад) эх үүсвэрээс олсон орлого [᠑52]

Сегментээр харуулсан, бусад сегментүүдтэй хийсэн ажил гүйлгээнээс үүссэн орлого [᠑52]

Сегментээр харуулсан, сегментийн хөрөнгүүдийн дансны үнэ [᠑53]

Сегментээр харуулсан, сегментийн өр төлбөрүүд [᠑54]

Сегментээр харуулсан, хөрөнгүүдийг олж эзэмших өртөг зардал [᠑55]

Сегментээр харуулсан, өмчийн аргаар тайлагнадаг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтын (бараг бүх үйл ажиллагаа нь тухайн нэг сегментийн хүрээнд хамаардаг бол) [᠑63] цэвэр ашиг (алдагдал) дахь хувь хэсэг [᠑61]

Сегментээр харуулсан, орлого, зардал, хөрөнгө, өр төлбөрийн тохируулгын тайлан [᠑64]

#### *Бусад тодруулга*

Сегмент хоорондын шилжүүлгийн үнэ тогтоох суурь ба түүний аливаа өөрчлөлт [᠑67]

Сегментийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт [᠑68]

Үйлчилгээний сегмент нэг бүрд тусган оруулсан бараа, үйлчилгээний төрөл [᠑73]

Газар зүйн сегмент нэг бүрийн бүтэц бүрэлдэхүүн [᠑73]

Сегментийн үйлчилгээний буюу газар зүйн суурийн аль алиныг хэрэглэдэггүй бол сегмент нэг бүрээр харуулсан, сегментийн болон түүнд хамаарах үйл ажиллагаануудын шинж төрөл [᠑73]

## **Санхүүгийн тайлагналын чанарын шинжүүд**

ХЗУ1. [Хассан]

ХЗУ2. [Хассан]

*Ойлгомжтой байх*

ХЗУ3. [Хассан]

ХЗУ4. [Хассан]

*Хамааралтай байх*

ХЗУ5. [Хассан]

*Материаллаг байдал*

ХЗУ6. [Хассан]

ХЗУ7. [Хассан]

*Найдвартай байдал*

ХЗУ8. [Хассан]

*Үнэн зөв толилуулах*

ХЗУ9. [Хассан]

*Хэлбэрээс илүү мөн чанар*

ХЗУ10. [Хассан]

*Төв голч*

ХЗУ11. [Хассан]

### **Хянамгай байдал**

ХЗУ12. [Хассан]

ХЗУ13. [Хассан]

*Иж бүрэн*

ХЗУ14. [Хассан]

*Зэрэгцүүлэгдэх боломжтой байх*

ХЗУ15. [Хассан]

ХЗУ16. [Хассан]

ХЗУ17. [Хассан]

ХЗУ18. [Хассан]

### **Хамааралтай ба найдвартай мэдээлэлд тавигдах хязгаарлалтууд**

#### *Цаг хугацаандаа байх*

ХЗУ19. Хэрэв мэдээллийн тайлагналыг хэт хожимдуулвал энэ нь өөрийн хамааралтай шинжийг алддаг. Мэдээллээр цаг хугацаанд нь хангахын тулд ажил гүйлгээний бүх төлөв байдлыг мэдэхээс өмнө түүнийг ихэвчлэн тайлагнах шаардлагатай болдог бөгөөд ингэснээр мэдээллийн найдвартай байдлыг бууруулдаг. Харин эсрэгээр, бүх төлөв байдал мэдэгдэх хүртэл тайлагналыг хойшлуулвал тухайн мэдээлэл нь ихээхэн найдвартай байж болох боловч энэ хооронд нэгэнт шийдвэрээ гаргасан хэрэглэгч нарт ач холбогдол багатай байдаг. Хамааралтай ба найдвартай байдлын хоорондох тэнцвэрт хүрэхийн тулд хамгийн гол анхаарах зүйл нь хэрэглэгчдийн шийдвэр гаргах хэрэгцээ шаардлагыг хэрхэн хамгийн сайнаар хангах эсэх явдал юм.ы

#### *Өгөөж ба өртөг зардлын хоорондох тэнцвэр*

ХЗУ20. Өгөөж ба өртөг зардлын хоорондох тэнцвэр нь нийтлэг хязгаарлалт юм. Мэдээллээс хүртэх өгөөж нь түүнийг бэлтгэх өртөг зардлаас илүү байвал зохино. Гэвч өгөөж ба өртөг зардлын үнэлгээ нь үндсэндээ шүүн тунгаалтын асуудал байдаг. Түүнчлэн, үр өгөөжийг хүртэж буй хэрэглэгч нар нь ямагт түүний өртөг зардлыг хариуцаад байдаггүй. Тодорхой хэрэглэгч нарт зориулан бэлтгэсэн мэдээллээс өөр хэрэглэгч нар бас өгөөж хүртэж болох юм. Энэ шалтгааны улмаас аливаа тохиолдол бүрд өртөг-өгөөжийн сорилыг хэрэглэхэд хүндрэлтэй байдаг. Хэдий тийм боловч стандарт тогтоогч нар, түүнчлэн санхүүгийн тайланг бэлтгэх хариуцлага хүлээсэн хүмүүс болон санхүүгийн тайлангийн хэрэглэгчид нь ийм хязгаарлалтыг мэддэг байвал зохино.

#### *Чанарын шинжүүдийн хоорондох тэнцвэр*

ХЗУ21. Практикт чанарын шинжүүдийн хоорондох тэнцвэр буюу харьцааг тогтоох нь ихэвчлэн зайлшгүй шаардлагатай байдаг. Ерөнхийдөө, зорилго нь санхүүгийн тайлангийн зорилтуудыг ханган биелүүлэхийн тулд чанарын шинжүүдийн хоорондох тохиромжтой тэнцвэрт хүрэх явдал юм. Өөр өөр тохиолдол дахь чанарын шинжүүдийн харьцангуй ач холбогдол нь мэргэжлийн шүүн тунгаалтын асуудал байдаг.

## **Үлгэрчилсэн жишээ**

*Энэхүү үлгэрчилсэн жишээ нь УСНББОУС 18-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

Энэ жишээнд харуулсан хүснэгт болон холбогдох тэмдэглэл нь үндсэндээ төсвийн хуваарилалтаар санхүүждэг боловч (а) томоохон компаниудын ажилтнуудад зарим боловсролын үйлчилгээг арилжааны сууриар үзүүлдэг, ба (б) арилжааны суриар үйл ажиллагаа эрхлэн явуулах хувийн хэвшлийн боловсролын санг байгуулахын тулд ашгийн төлөө хамтарсан үйлдвэрт хувь оруулсан боловсролын эрх бүхий байууллагын хувьд энэ Стандартаар шаардах сегментийн тодруулгыг үлгэрчлэн харуулсан. Тус эрх бүхий байгууллага нь тэрхүү санд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх боловч түүнийг хянадаггүй. Үлгэрчлэн харуулах зорилгоор хоёр жилийн зэрэгцүүлсэн мэдээг энэ жишээнд толилуулсан. Иж бүрэн санхүүгийн тайланг толилуулж буй жил бүрийн хувьд сегментийн мэдээ бэлтгэхийг шаардана.

СЕГМЕНТИЙН ТАЙЛАГНАЛ

Хүснэгт А – Сегментийн талаархи мэдээлэл (сая мөнгөн нэгжээр)

	Анхан/дунд түвшин		Ахисан түвшин		Тусгай үйлчилгээ		Бусад үйлчилгээ		Устгалт		Нэгтгэсэн дүн	
	20X2	20X1	20X2	20X1	20X2	20X1	20X2	20X1	20X2	20X1	20X2	20X1
<b>СЕГМЕНТИЙН ОРЛОГО</b>												
Төвийн хуваарилалт	48	40	22	23	10	10	7	7				
Гаднын эх үүсвэрээс олох хураамж	5	4	-	-	9	6	-	-				
Сегмент хоорондын шилжүүлэг	10	6	6	7	2	4	2	2				
<b>Сегментийн орлогын дүн</b>	<b>63</b>	<b>50</b>	<b>28</b>	<b>30</b>	<b>21</b>	<b>20</b>	<b>9</b>	<b>9</b>	<b>20</b>	<b>19</b>	<b>101</b>	<b>90</b>
<b>СЕГМЕНТИЙН ЗАРДАЛ</b>												
Цалин хөлс	(39)	(31)	(13)	(13)	(13)	(13)	(2)	(2)				
Элэгдэл	(9)	(7)	(5)	(7)	(5)	(3)	(1)	(1)				
Бусад зардал	(12)	(11)	(10)	(9)	(5)	(5)	(2)	(2)				
<b>Сегментийн зардлын дүн</b>	<b>(60)</b>	<b>(49)</b>	<b>(28)</b>	<b>(29)</b>	<b>(23)</b>	<b>(21)</b>	<b>(5)</b>	<b>(5)</b>	<b>20</b>	<b>19</b>	<b>(96)</b>	<b>(85)</b>
Төвийн хуваарилалдаагүй зардал											<u>(7)</u>	<u>(9)</u>
Үндсэн үйл ажиллагааны алдагдал											(2)	(4)
Хүүний зардал											(4)	(3)
Хүүний орлого											2	3



СЕГМЕНТИЙН ТАЙЛАГНАЛ

	Анхан/дунд түвшин		Ахисан түвшин		Тусгай үйлчилгээ		Бусад үйлчилгээ		Устгалт		Нэгтгэсэн дүн	
	20X2	20X1	20X2	20X1	20X2	20X1	20X2	20X1	20X2	20X1	20X2	20X1
Хараат байгууллагуудын цэвэр ашиг дахь хувь хэсэг							8	7			8	7
<b>Тайлант үеийн ашиг</b>											4	3
<b>БУСАД МЭДЭЭЛЭЛ</b>												
Сегментийн хөрөнгө	54	50	34	30	10	10	10	9			108	99
Хараат байгууллагууд дахь хөрөнгө оруулалт (өмчийн аргаар)							32	26			32	26
Төвийн хуваарилагдаагүй зардал											35	30
<b>Нэгтгэсэн нийт хөрөнгө</b>											175	155
Сегментийн өр төлбөр	25	15	8	11	8	8	1	1			42	35
Компанийн хуваарилагдаагүй өр төлбөр											40	55
<b>Нэгтгэсэн нийт өр төлбөр</b>											82	90
Капитал зарлага	13	10	9	5	4	0	2	3				
Мөнгөн бус зардал, үүнд элэгдэл хамаарахгүй	(8)	(2)	(3)	(3)	(2)	(2)	(1)	(1)				
Мөнгөн бус орлого	-	-	-	-	1	1	-	-				

## СЕГМЕНТИЙН ТАЙЛАГНАЛ

Тус эрх бүхий байгууллага нь анхан ба дунд түвшний боловсрол, ахисан түвшний боловсрол, тусгай боловсролын үйлчилгээ, бусад үйлчилгээ гэсэн чиг үүргийн гол дөрвөн талбараар зохион байгуулагдаж, өөрийн удирдах зөвлөлд тайлагнадаг бөгөөд чиг үүргийн талбар нэг бүрийг захирал удирддаг. Томоохон компаниудын ажилтнуудад арилжааны сууриар үзүүлэх боловсролын үйлчилгээ нь тусгай боловсролын үйлчилгээний үйл ажиллагааны цар хүрээнд хамаардаг. Ийм үйлчилгээг гаднын талуудад үзүүлэхдээ тус сегментийн арилжааны үйлчилгээний нэгж нь анхан/дунд түвшний болон ахисан түвшний боловсролын сегментүүдийн үйлчилгээг төлбөртэйгээр авч ашигладаг. Нэгтгэл хийхдээ эдгээр сегмент хоорондын шилжүүлгийг устгадаг.

Удирдах зөвлөл болон дээд түвшний удирдлага нь өөрийн зорилтуудад хүрэхдээ тухайн байгууллагын хийсэн өнгөрсөн гүйцэтгэлийг үнэлэх ба нөөцийн ирээдүйн хуваарилалтын талаар шийдвэр гаргах суурь үндэслэл болгон эдгээр сегментүүдийн талаар тайлагнасан мэдээллийг ашигладаг. Эдгээр сегментүүдийн талаархи мэдээллийн тодруулга нь гаднын тайлагналын зорилгын хувьд мөн тохиромжтой гэж үздэг.

Дунд түвшний боловсролын үйлчилгээ үзүүлэхийн тулд тусламжийн хөтөлбөрийн нэг хэсэг байдлаар Зүүн Европт байгуулсан нэгжээс бусад, уг эрх бүхий байгууллагын ихэнх үйл ажиллагаа дотоодод явагддаг. Зүүн Европт үзүүлсэн үйлчилгээний нийт өртөг нь 5 сая (20X1 онд 4 сая) мөнгөн нэгж байсан. Зүүн Европ дахь боловсролын нэгжийн нийт дансны үнэ нь 3 сая (20X1 онд 6.5 сая) мөнгөн нэгж байна. Зүүн Европт 20X2 болон 20X1 онд капитал хөрөнгө худалдан авахад ямар нэг зарлага гаргаагүй.

Сегмент хоорондын шилжүүлэг: сегментийн орлого ба сегментийн зардалд сегментүүдийн хоорондох шилжүүлгээс үүссэн орлого, зардал хамаардаг. Ийм шилжүүлгийг ихэвчлэн өртгөөр тайлагнадаг бөгөөд нэгтгэл хийхдээ устгадаг. Эдгээр шилжүүлгийн дүн нь 20 сая (19X1 онд 19 сая) мөнгөн нэгж байсан.

Хараат байгууллага дахь хөрөнгө оруулалтыг өмчийн арга ашиглан тайлагнадаг. Олон талын оролцоотой зээлийн агентлагуудад гэрээний дагуу боловсролын үйлчилгээг олон улсад арилжааны сууриар үзүүлдэг, боловсролын мэргэшсэн сан болох ЕвроИД ХХК-ийн өмчийн хувьцааны 40 хувийг тус эрх бүхий байгууллага өмчилдөг. Энэхүү хөрөнгө оруулалтыг өмчийн аргаар тайлагнадаг. ЕвроИД ХХК-д оруулсан хөрөнгө оруулалт, түүнчлэн тус компанийн цэвэр ашиг дахь уг Эрх бүхий байгууллагын хувь хэсгийг сегментийн хөрөнгө болон сегментийн орлогод тусган оруулдаггүй.

Харин хараат байгууллага дахь хөрөнгө оруулалтыг удирдах үүрэг хариуцлага бүхий бусад үйлчилгээний сегментэд тэдгээрийг тусад нь харуулдаг.

Сегмент нэг бүрийн хувьд тогтоосон зорилтууд болон тэдгээр зорилтуудын хэрэгжилтийн хэмжээг Үйл Ажиллагааны Тоймд тусгадаг бөгөөд түүнийг энэхүү тайлангийн аль нэг хэсэгт харуулдаг.

## НББОУС 14-ТЭЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 18-ыг НББОУС 14 (1997 онд хянан засварласан)-өөс үндсэндээ бэлтгэсэн. УСНББОУС 18 ба НББОУС 14-ийн хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- УСНББОУС 18 нь сегментийг НББОУС 14-д зааснаас өөрөөр тодорхойлдог. УСНББОУС 18 нь өнгөрсөн гүйцэтгэлийг үнэлэх ба нөөцийн хуваарилалтын талаар шийдвэр гаргахад тохиромжтой сууриар сегментийг тайлагнахыг байгууллагуудаас шаарддаг. НББОУС 14 нь бизнесийн болон газар зүйн сегментүүдийг тайлагнахыг шаарддаг.
- НББОУС 14 нь сегментийн үр дүн, сегментийн хөрөнгүүдийн элэгдэл ба хорогдуулга, бусад мөнгөн бус мэдэгдэхүйц зардлын тодруулга хийхийг шаарддаг. УСНББОУС 18 нь сегментийн үр дүнгийн талаар тодруулга хийхийг шаарддаггүй. УСББНОУС 18 нь сегментийн орлогод тусгасан томоохон мөнгөн бус орлого, сегментийн элэгдлийн зардал болон бусад мөнгөн бус зардал буюу УСНББОУС 2, *Мөнгөн Гүйлгээний Тайлан*-гаар шаардсан сегментийн мөнгөн гүйлгээний тодруулга хийхийг сайшаан дэмждэг боловч заавал хийхийг шаарддаггүй.
- УСНББОУС 18 нь хоёрдогч сегментийн талаархи мэдээллийн тодруулгыг шаарддаггүй боловч үйлчилгээний болон газар зүйн сегментүүдийн аль алины талаархи хамгийн наад захын зарим тодруулга хийхийг сайшаан дэмждэг.
- УСНББОУС 18 нь тайлагнах сегментүүдийг тодорхойлохдоо мөрдөх ёстой тоон босго шалгуурыг тусгайлан заагаагүй.
- УСНББОУС 18 нь зарим тохиолдолд НББОУС 14-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь УСНББОУС 18 дахь “орлого” /revenue/, “санхүүгийн үр дүнгийн тайлан”, “цэвэр хөрөнгө/өмч” гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. НББОУС 14 дэх адилтгах нэр томъёо нь “орлого” /income/, “орлогын тайлан”, “өмч” юм.

## УСНББОУС 19–НӨӨЦ, БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА БОЛЗОШГҮЙ ХӨРӨНГӨ

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) 37, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө* (1998)-өөс үндсэндээ бэлтгэсэн болно. НББОУС 37-гоос авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон ЕС4М 6ХН, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)

Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.

## УСНББОУС 19-НӨӨЦ, БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА БОЛЗОШГҮЙ ХӨРӨНГӨ

### УСНББОУС-ЫН ТҮҮХ

Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

УСНББОУС 19, Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө-ийг 2002 оны 10 дугаар сард гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 19-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл (2017 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 39, Ажилтны Тэтгэмж (2016 оны 7 дугаар сард гаргасан)
- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 37, Хамтын Хэлэлцээр (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2011-ийн Сайжруулалтууд (2011 оны 10 дугаар сард гаргасан)
- УСНББОУС 3, Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа (2006 оны 12 дугаар сард гаргасан)
- УСНББОУС 14, Тайлангийн Өдрийн Дараах Үйл Явдал (2006 оны 12 дугаар сард гаргасан)

### УСНББОУС 19-ийн нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт

Өөрчлөгдсөн параграф	Хэрхэн өөрчилсөн	Юугаар өөрчилсөн
1	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
2	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
3	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
4	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
4А	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар

НӨӨЦ, БОЛЗОШГУЙ ӨР ТӨЛБӨР БА БОЛЗОШГУЙ ХӨРӨНГӨ

5	Хассан	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
6	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
14	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 39, 2016 оны 7-р сар
22	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
37	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар
87	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 14, 2006 оны 12-р сар
110	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
111 <sup>1</sup>	Хассан	УСНББОУС 3, 2006 оны 12-р сар
111А	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
111Б	Шинэ	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
111В	Шинэ	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар
111Г	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
111Д	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
111Е	Шинэ	УСНББОУС 39, 2016 оны 7-р сар
111Ж	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
112	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
ХЗУ14	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар

<sup>1</sup> 111-р параграф нь шилжилтийн нөхцөл юм. Дараагийн параграфуудыг дахин дугаарласан.

2002 оны 10 дугаар сар

**УСНББОУС 19–НӨӨЦ, БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА  
БОЛЗОШГҮЙ ХӨРӨНГӨ**

**АГУУЛГА**

	Параграф
Зорилго	
Цар хүрээ	1-17
Нийгмийн халамж	7-11
Энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй бусад зүйлс	12-17
Тодорхойлолт	18-21
Нөөц ба бусад өр төлбөр	19
Нөөц ба болзошгүй өр төлбөрийн хоорондох хамаарал	20-21
Хүлээн зөвшөөрөлт	22-43
Нөөц	22-34
Одоогийн үүрэг	23-24
Өнгөрсөн үйл явдал	25-30
Эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцийн магадлалт зарцуулалт	31-32
Үүргийн найдвартай тооцоолол	33-34
Болзошгүй өр төлбөр	35-38
Болзошгүй хөрөнгө	39-43
Хэмжилт	44-62
Хамгийн сайн тооцоолол	44-49
Эрсдэл ба тодорхой бус байдал	50-52
Өнөөгийн үнэ цэнэ	53-57
Ирээдүйн үйл явдлууд	58-60
Хөрөнгийн хүлээгдэж буй данснаас хасалт	61-62
Нөхөн төлбөр	63-68
Нөөцийн өөрчлөлт	69-70
Нөөцийн ашиглалт	71-72
Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийн дүрмүүдийг мөрдөх	73-96
Ирээдүйн үйл ажиллагааны цэвэр алдагдал	73-75
Алдагдалтай гэрээ	76-80
Бүтцийн өөрчлөлт	81-96
Үйл ажиллагааны борлуулалт буюу шилжүүлэлт	90-92
Бүтцийн өөрчлөлтийн нөөц	93-96
Тодруулга	97-109
Шилжилтийн нөхцөл	110
Хүчин төгөлдөр болох хугацаа	111-112
Хүснэгт	
Үлгэрчилсэн шийдвэрийн мод	
Дүгнэлтийн үндэслэл	
Хэрэгжүүлэх заавар удирдамж	
Үлгэрчилсэн жишээ	
НББОУС 37-той харьцуулалт	

## НӨӨЦ, БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА БОЛЗОШГҮЙ ХӨРӨНГӨ

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-ийг түүний зорилго хэсэг болон 1-112-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 19-ийг түүний зорилгын агуулга, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.



## Зорилго

Энэ Стандартын зорилго нь (а) нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгийг тодорхойлох, (б) нөөцийг хүлээн зөвшөөрвөл зохих нөхцөл байдал, тэдгээрийг хэрхэн хэмжих ба тэдний талаар хийх хэрэгтэй тодруулгыг тодорхойлоход оршино. Мөн энэ Стандарт нь болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгийн шинж төрөл, хугацаа, дүнг ойлгох боломжийг хэрэглэгчдэд олгохын тулд тэдний талаархи зарим мэдээллийг санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тодруулахыг шаарддаг.

## Цар хүрээ

1. **Нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь доор дурдсанаас бусад нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгийн тайлагналд энэхүү Стандартыг мөрдөнө:**
  - (а) **Нийлүүлсэн бараа, үйлчилгээнийхээ үнэ цэнэтэй ойролцоогоор тэнцүү төлбөрийг тэдгээр үр өгөөж хүртэгчдээс хариу болгон шууд хүлээн авдаггүй байгууллагын үзүүлсэн нийгмийн халамжаас үүсэх нөөц ба болзошгүй өр төлбөр;**
  - (б) **[Хассан];**
  - (в) **Энэ параграфын бусад заалтуудад хамаарах алдагдалтай гэрээнээс бусад, бүрэн биелэгдээгүй гэрээнээс үүссэн нөөц, болзошгүй өр төлбөр, болзошгүй хөрөнгө;**
  - (г) **Даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартын цар хүрээнд хамаарах даатгалын гэрээ;**
  - (д) **Өөр Стандартын хүрээнд авч үзсэн нөөц, болзошгүй өр төлбөр, болзошгүй хөрөнгө;**
  - (е) **Орлогын татвар буюу орлогын татвартай адилтгах татвартай холбоотойгоор үүссэн нөөц, болзошгүй өр төлбөр, болзошгүй хөрөнгө;**
  - (ж) **Энэ Стандартаар зохицуулсан ба бүтцийн өөрчлөлтийн үр дүнд үүсэх ажилтны ажлаас халагдалтын тэтгэмжээс бусад, ажилтны тэтгэмжтэй холбоотой нөөц, болзошгүй өр төлбөр, болзошгүй хөрөнгө.**
2. [Хассан]
3. [Хассан]
4. **УСНББОУС 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*-ийн цар хүрээнд хамаарах санхүүгийн хэрэглүүрт (үүн дотроо баталгаанд) энэ Стандартыг мөрдөхгүй.**

- 4А. УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийн цар хүрээнд хамаарах улсын секторын нэгдэл дэх нэгтгэгчийн болзошгүй төлбөрт энэ Стандартыг мөрдөхгүй.
5. [Хассан]
6. Энэ Стандартыг бүтцийн өөрчлөлтийн (үүн дотроо зогсоосон үйл ажиллагааны) нөөцийн хувьд мөрдөнө. Байгууллага нь бүтцийн өөрчлөлтийн санхүүгийн үр нөлөөг үнэлэх боломжийг өөрийн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгох мэдээллийг тодруулна.

### **Нийгмийн халамж**

7. Энэ Стандартын зорилгын хувьд “нийгмийн халамж” гэдэг нь засгийн газрын нийгмийн бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх явцад нийлүүлсэн бараа, үйлчилгээ болон бусад үр өгөөжийг хэлнэ. Ийм халамжинд дараах зүйлс хамаарч болно:
- (а) Тухайн нийгэмд эрүүл мэнд, боловсрол, орон байр, тээврийн болон бусад нийгмийн үйлчилгээ үзүүлэх. Ихэнх тохиолдолд энэ нь тэдгээр үйлчилгээний үнэ цэнэтэй адилтгах дүн төлөхийг уг үйлчилгээ хүлээн авагчдаас шаарддаггүй; ба
  - (б) Гэр бүл, өндөр настан, тахир дутуу иргэд, ажилгүйчүүд, ахмад дайчид болон бусад иргэдэд олгосон тэтгэмжийн төлбөр. Өөрөөр хэлбэл, бүх түвшний засаг захиргааны байгууллага нь тухайн нийгмийн иргэд болон тодорхой бүлэг хүмүүст санхүүгийн туслалцаа үзүүлж, тэднийг өөрсдийн тухайлсан хэрэгцээ шаардлагаа хангах буюу орлогоо нэмэгдүүлэхийн тулд үйлчилгээ авах боломжийг олгодог.
8. Ихэнх тохиолдолд, нийгмийн халамж үзүүлэх үүрэг нь тухайн нийгэмд тодорхой бараа, үйлчилгээ нийлүүлэхийн тулд урт хугацааны туршид тасралтгүй байдлаар зарим тодорхой үйл ажиллагааг эрхлэн явуулах засгийн газрын баталгааны үр дагавар болон үүсдэг. Нийгмийн бодлогын үүргийг биелүүлэхэд чиглэгдсэн бараа, үйлчилгээний хэрэгцээ шаардлага, шинж төрөл, ханган нийлүүлэлт нь хүн ам зүйн болон нийгмийн янз бүрийн нөхцөл байдлуудаас ямагт хамаардаг бөгөөд урьдчилан тодорхойлоход төвөгтэй байдаг. Олон Улсын Валютын Сангаас гаргасан Засгийн Газрын Санхүүгийн Статистикийн үзэл баримтлалын дагуу эдгээр халамж тэтгэмж нь нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэнд гэсэн ангилалуудад ерөнхийдөө хамаардаг бөгөөд тэдгээрийн хувьд үүсэх аливаа өр төлбөрийн дүнг тодорхойлохын тулд ихэвчлэн актуар үнэлгээ хийх шаардлагатай байдаг.
9. Энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй нийгмийн халамжаас үүсэх нөөц буюу болзошгүй өр төлбөрийн хувьд, тэрхүү тэтгэмжийг олгож буй улсын секторын байгууллага нь нийлүүлсэн бараа, үйлчилгээнийхээ үнэ цэнэтэй ойролцоогоор тэнцүү төлбөрийг тэдгээр үр өгөөж хүртэгчдээс хариу болгон шууд хүлээн авдаггүй. Тухайн үр өгөөжийн хувьд төлбөр

ногдуулдаг боловч төлбөр ба хүлээн авсан үр өгөөж нь шууд холбоогүй байх тэдгээр нөхцөл байдлууд нь Стандартын цар хүрээнд хамаарахгүй ийм нөхцөлд хамаарах юм. Эдгээр нөөц болон болзошгүй өр төлбөрийг энэ Стандартын цар хүрээнд оруулахгүй хасаж байгаа нь (а) үүрэг хүлээлгэх үйл явдлыг юу бүрдүүлдэг талаархи тодорхойлолт, (б) тухайн өр төлбөрийн хэмжилт нь санал болгосон Стандартыг танилцуулан санал авахаас өмнө цаашид харгалзан үзэх шаардлагатай гэсэн Хорооны үзэл баримтлалыг тусган илэрхийлнэ. Жишээлбэл; хувь хүн нь халамж тэтгэмж авах зохих шалгуурыг хангах буюу үүнээс өмнөх тодорхой нэг үе шатанд уг үүрэг хүлээлгэх үйл явдал гарч тохиолдсон эсэх талаар янз бүрийн үзэл бодолтой байдаг гэдгийг Хороо хүлээн зөвшөөрдөг. Үүнтэй адилаар, аливаа үүргийн дүн нь тухайн тайлант үед үүссэн эрхийн тооцоолол эсвэл актуар сууриар тодорхойлсон, ирээдүйн хүлээгдэж буй бүх тэтгэмжийн өнөөгийн үнэ цэнийг тусгасан эсэх талаар өөр өөр үзэл бодолтой байдаг.

10. Байгууллага нь ийм үүргийн хувьд нөөц хүлээн зөвшөөрөх сонголт хийсэн тохиолдолд тухайн байгууллага нь тэрхүү нөөцийг хүлээн зөвшөөрсөн суурь болон хэрэглэсэн хэмжилтийн суурийг тодруулна. Байгууллага нь тэдгээр нөөцийн хувьд энэ Стандартаар шаардсан бусад тодруулгыг бас хийнэ. Бусад УСНББОУС-аар тусгайлан авч үзээгүй асуудлуудын зохицуулалтын талаархи заавар удирдамжийг УСНББОУС 1-д тусгасан. УСНББОУС 1 нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын сонголт ба тодруулгатай холбоотой шаардлагуудыг мөн тусгасан байдаг.
11. Зарим тохиолдолд, нийгмийн халамж нь өр төлбөр үүсэхэд хүргэж болох бөгөөд тэрхүү өр төлбөрийн хувьд:

- (а) Дүн нь тодорхойгүй биш буюу бага зэрэг тодорхойгүй байна; ба  
(б) Үүргийн дүн нь тодорхойгүй биш байна.

Иймээс эдгээр нь энэ Стандарт дахь нөөцийн тодорхойлолтыг хангах магадлал багатай юм. Нийгмийн халамжийн хувьд ийм өр төлбөр оршин байх тохиолдолд өр төлбөр гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангасан үед тэдгээрийг хүлээн зөвшөөрнө (19-р параграфыг бас үзнэ үү). Жишээлбэл; гэрээ буюу хууль тогтоомжийн заалтын дагуу төлбөрийг төлөхөөр зөвшөөрөн баталсан өндөр настан болон тахир дутуу иргэдийн тэтгэврийн хувьд одоогийн тэтгэмж авагчдад төлөх тухайн тайлант үеийн эцэс дэх хуримтлуулсан дүн.

### **Энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй бусад зүйлс**

12. Алдагдалтай гэрээ байхаас бусад тохиолдолд энэ Стандартыг бүрэн биелэгдээгүй гэрээнд мөрдөхгүй. Нийлүүлсэн бараа, үйлчилгээнийхээ үнэ цэнэтэй ойролцоогоор тэнцүү төлбөрийг байгууллага нь тэдгээр үр өгөөж хүртэгчдээс хариу болгон шууд хүлээн авахгүй гэсэн хүлээлттэйгээр байгуулсан ба нийгмийн халамж үзүүлэх гэрээ нь энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй.

13. Нөөц, болзошгүй өр төлбөр, болзошгүй хөрөнгийн тодорхой нэг төрлийг өөр бусад УСНББОУС-аар авч үзсэн тохиолдолд байгууллага нь энэ Стандартыг биш, харин тэрхүү бусад Стандартыг мөрдөнө. Жишээлбэл; дараах зүйлсийн талаархи холбогдох Стандартуудад зарим төрлийн нөөцийг авч үзсэн байдаг:
  - (а) Барилгын гэрээ (УСНББОУС 11 *Барилгын Гэрээ*-г үзнэ үү); ба
  - (б) Түрээс (УСНББОУС 13 *Түрээс*-ийг үзнэ үү). Гэвч УСНББОУС 13 нь алдагдалтай болсон үйл ажиллагааны түрээсийг тайлагнах талаархи тусгай шаардлагуудыг агуулаагүй байдаг тул тэдгээр тохиолдолд энэ Стандартыг мөрдөнө.
14. Орлогын албан татвар буюу орлогын татвартай адилтгах татварын нөөцөд энэ Стандартыг мөрдөхгүй (орлогын албан татварын тайлагналын талаархи заавар удирдамжийг НББОУС 12, *Орлогын Албан Татвар*-аас үзэж болно). Мөн ажилтны тэтгэмжээс үүссэн нөөцөд энэ Стандартыг мөрдөхгүй (ажилтны тэтгэмжийн тайлагналын талаархи заавар удирдамжийг УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ээс олж үзэж болно).
15. Нөөц гэж үзэж буй зарим дүн нь тухайлбал, байгууллага нь хураамж авснаар баталгаа гаргаж өгсөн тохиолдолд орлогын хүлээн зөвшөөрөлттэй холбоотой байж болно. Орлогын хүлээн зөвшөөрөлтийг энэ Стандартад авч үзэхгүй. УСНББОУС 9, *Арилжааны Ажил Гүйлгээний Орлого* нь арилжааны ажил гүйлгээнээс үүссэн орлогыг хүлээн зөвшөөрөх нөхцөл байдлуудыг тодорхойлдог бөгөөд хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг мөрдөх талаархи практик заавар удирдамжаар хангадаг. Энэ Стандарт нь УСНББОУС 9-ийн шаардлагуудыг өөрчлөхгүй юм.
16. Энэ Стандарт нь нөөцийг цаг хугацаа буюу дүнгийн хувьд тодорхой бус өр төлбөр гэж тодорхойлдог. Зарим улс оронд “нөөц” гэсэн нэр томъёог элэгдэл, хөрөнгийн үнэ цэнийн бууралт, найдваргүй авлага гэх мэт зүйлсийн хүрээнд мөн хэрэглэдэг. Эдгээр нь хөрөнгийн дансны үнийн тохируулга бөгөөд энэ Стандартад авч үзэхгүй.
17. Зарлагыг хөрөнгө эсвэл зардал гэж үзэх эсэхийг бусад УСНББОУС-уудад тусгайлан заасан байдаг. Тэдгээр асуудлуудыг энэ Стандартад авч үзэхгүй. Иймээс энэ Стандарт нь нөөц байгуулах үед өртөг зардлыг капиталжуулахыг хориглохгүй, мөн шаардахгүй юм.

## Тодорхойлолт

18. **Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:**

**Гэрээний бус үүрэг гэдэг нь дараах тохиолдолд байгууллагын үйл ажиллагааны үр дүнд үүсдэг үүрэг юм:**

- (а) **Өнгөрсөн практикын тогтсон хэв маяг, хэвлэн нийтэлсэн бодлого буюу хангалттай тодорхой заасан одоогийн**

мэдэгдлээр тухайн байгууллага нь зарим хариуцлагыг хүлээнэ гэдгээ бусад талуудад илэрхийлсэн байх;

- (б) Үүний үр дүнд, уг байгууллага нь тэдгээр хариуцлагыг биелүүлнэ гэсэн бодит хүлээлтийг нөгөө талдаа бий болгосон байх.

Болзошгүй хөрөнгө гэдэг нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүсдэг бөгөөд түүний оршин байдал нь бүхэлдээ уг байгууллагын хянах боломжгүй ирээдүйн нэг буюу хэд хэдэн тодорхой бус үйл явдлын тохиолдолт эсвэл үл тохиолдолтоор зөвхөн батлагдах боломжит хөрөнгө юм.

Болзошгүй өр төлбөр гэдэг нь:

- (а) Өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүсдэг бөгөөд түүний оршин байдал нь бүхэлдээ уг байгууллагын хянах боломжгүй ирээдүйн нэг буюу хэд хэдэн тодорхой бус үйл явдлын тохиолдолд эсвэл үл тохиолдолтоор зөвхөн батлагдах боломжит үүрэг; эсвэл
- (б) Өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүсдэг боловч дараах шалтгааны улмаас хүлээн зөвшөөрөөгүй одоогийн үүрэг:
- (i) Уг үүргийг барагдуулахад шаардлагатай эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцийг зарцуулах магадлалгүй; эсвэл
- (ii) Үүргийн дүнг хангалттай найдвартай<sup>2</sup> хэмжих боломжгүй.

Бүрэн биелэгдээгүй гэрээ гэдэг нь аль нэг тал өөрийн ямар нэг үүргийг биелүүлээгүй эсвэл хоёр талын аль аль нь өөрсдийн үүргийг адил тэнцүү хэмжээгээр хэсэгчлэн биелүүлсэн гэрээ юм.

Хуулиар хүлээсэн үүрэг гэдэг нь дараах зүйлсээс үүсдэг үүрэг юм:

- (а) Гэрээ (түүний илэрхий буюу далд утгатай нөхцлөөр);
- (б) Хууль тогтоомж; эсвэл
- (в) Хуулийн бусад үйлчлэл.

Үүрэг хүлээлгэх үйл явдал гэдэг нь тухайн үүргийг барагдуулахаас өөр бодит сонголтгүй болоход уг байгууллагыг хүргэдэг, хуулиар хүлээсэн үүрэг эсвэл гэрээний бус үүрэг үүсгэдэг тийм үйл явдал юм.

---

<sup>2</sup> Найдвартай мэдээлэл нь материаллаг алдаа ба туйлшралаас ангид байх бөгөөд өөрийн илэрхийлэхээр зориулагдсан буюу илэрхийлнэ гэж үл үндэслэлтэйгээр хүлээж болох зүйлсийг үнэн зөв илэрхийлэхдээ хэрэглэгчдээс хамаардаг байж болох юм. Найдвартай байдлын тайлбарын талаархи шилжилтийн арга хандлагыг УСНББОУС 1-ийн ДҮ16-р параграфт авч хэлэлцсэн.

**Алдагдалтай гэрээ** гэдэг нь гэрээний үүргийг биелүүлэхэд гарах, зайлсхийх боломжгүй зардал нь уг гэрээний дагуу авахаар хүлээгдэж буй эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхиас хэтрэх, хөрөнгийн болон үйлчилгээний арилжааны гэрээ юм.

**Нөөц** гэдэг нь тодорхой бус хугацаа буюу дүн бүхий өр төлбөр юм.

**Бүтцийн өөрчлөлт** гэдэг нь удирдлага төлөвлөн хянаж байгаа бөгөөд дараах зүйлсийн аль нэгийг материаллагаар өөрчлөх хөтөлбөр юм:

- (а) Байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ; эсвэл
- (б) Тэдгээр үйл ажиллагааг эрхлэн явуулдаг арга маяг.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь-д* дахин нийтэлсэн болно.

### **Нөөц ба бусад өр төлбөр**

19. Нөөцийг барагдуулахад шаардлагатай ирээдүйн зарлагын цаг хугацаа буюу дүн тодорхой бус байдаг учраас түүнийг худалдааны өглөг, хуримтлагдсан өглөг гэх мэт бусад өр төлбөрөөс ялган зааглаж болно. Харин эсрэгээр:

- (а) Худалдааны өглөг нь хүлээн авсан буюу нийлүүлэгдсэн бараа, үйлчилгээний төлбөрийг төлөх өр төлбөр бөгөөд бэлтгэн нийлүүлэгч нь нэхэмжилсэн буюу түүнтэй албан ёсоор тохиролцсон байдаг (тусгайлан заасан дүнгийн талаархи албан ёсны гэрээ хийсэн тохиолдолд нийгмийн халамжийн хувьд хийгдэх төлбөрүүд үүнд хамаарна); ба
- (б) Хуримтлагдсан өглөг нь хүлээн авсан буюу нийлүүлэгдсэн бараа, үйлчилгээний төлбөрийг төлөх өр төлбөр боловч түүнийг төлөөгүй, нэхэмжлээгүй буюу бэлтгэн нийлүүлэгчтэй албан ёсоор тохиролцоогүй байх бөгөөд ажилтнуудад төлөх өглөг (жишээлбэл; хуримтлагдсан амралтын цалинтай холбоотой дүн) үүнд хамаарна. Хэдийгээр хуримтлагдсан өглөгийн дүн буюу хугацааг зарим үед тооцоолох шаардлагатай байдаг боловч түүний тодорхойгүй байдал нь нөөцөөс ерөнхийдөө бага байдаг.

Хуримтлагдсан өглөгийг ихэвчлэн худалдааны өглөгийн нэг хэсэг байдлаар тайлагнадаг бол нөөцийг тусад нь тайлагнадаг.

### **Нөөц ба болзошгүй өр төлбөрийн хоорондох хамаарал**

20. Ерөнхий утгаараа бүх нөөц нь цаг хугацаа буюу дүнгийн хувьд тодорхой бус учраас болзошгүй шинжтэй байдаг. Гэвч энэхүү Стандартын хүрээнд “болзошгүй” гэсэн нэр томъёог хөрөнгө, өр төлбөрийн оршин байдал нь бүхэлдээ тухайн аж ахуйн нэгжийн хянах боломжгүй ирээдүйн нэг буюу хэд хэдэн тодорхой бус үйл явдлын тохиолдолд эсвэл үл тохиолдолтоор

зөвхөн батлагдах тул хүлээн зөвшөөрөөгүй байгаа тийм хөрөнгө, өр төлбөрийн хувьд хэрэглэнэ. Түүнчлэн, “болзошгүй өр төлбөр” гэсэн нэр томъёог хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангахгүй өр төлбөрийн хувьд хэрэглэнэ.

21. Энэ Стандартад дараах зүйлсийг өөр хооронд нь ялган тодорхойлсон:
- (a) Нөөц – энэ нь одоогийн үүрэг бөгөөд уг үүргийг барагдуулахад шаардлагатай эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцийг зарцуулах нилээд магадлалтай тул өр төлбөр гэж хүлээн зөвшөөрдөг (найдвартай тооцоолол хийж чадна гэж үздэг); ба
  - (б) Болзошгүй өр төлбөр – энэ нь дараах зүйлсийн аль нэг байх учраас өр төлбөр гэж хүлээн зөвшөөрөхгүй:
    - (i) Тухайн байгууллага нь эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцийг зарцуулахад хүргэж болох одоогийн үүрэгтэй эсэхийг хараахан батлаагүй байгаа тул боломжит үүрэг; эсвэл
    - (ii) Энэ Стандартын хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангахгүй одоогийн үүрэг (яагаад гэвэл, уг үүргийг барагдуулахын тулд эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцийг зарцуулах магадлалгүй эсвэл үүргийн дүнгийн талаар хангалттай найдвартай тооцооллыг хийж чадахгүй).

## **Хүлээн зөвшөөрөлт**

### **Нөөц**

22. **Дараах тохиолдолд нөөцийг хүлээн зөвшөөрнө:**
- (a) **Байгууллага нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд одоогийн (хуулиар хүлээсэн эсвэл гэрээний бус) үүрэгтэй байх;**
  - (б) **Үүргийг барагдуулахад шаардлагатай эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцийг зарцуулах нилээд магадлалтай байх;**
  - (в) **Үүргийн дүнгийн талаар найдвартай тооцоолол хийж чадах.**
- Хэрэв эдгээр нөхцлүүд хангагдахгүй бол нөөцийг хүлээн зөвшөөрөхгүй.**

### *Одоогийн үүрэг*

23. **Зарим тохиолдолд одоогийн үүрэгтэй эсэх нь тодорхойгүй байдаг. Ийм тохиолдолд бэлэн, боломжтой байгаа бүх нотолгоог харгалзан үзсэнээр тухайн тайлангийн өдрөөр одоогийн үүрэг оршин байх нь үл оршин байхаас илүү их магадлалтай бол өнгөрсөн үйл явдал нь одоогийн үүрэг үүсэхэд хүргэнэ гэж төсөөлдөг.**

24. Ихэнх тохиолдолд өнгөрсөн үйл явдал нь одоогийн үүрэг үүсэхэд хүргэсэн эсэх нь тодорхой байдаг. Зарим тохиолдолд, жишээлбэл шүүхээр шийдэгдэх зарга маргааны хувьд тодорхой үйл явдал гарч тохиолдсон эсвэл тэдгээр үйл явдлууд нь одоогийн үүргийг үүсгэх эсэх талаар маргаж болох юм. Ийм тохиолдолд, байгууллага нь бэлэн, боломжтой байгаа бүх нотолгоог, үүн дотроо тухайлбал, шинжээчийн дүгнэлтийг харгалзан үзсэнээр тухайн тайлангийн өдрөөр одоогийн үүрэг оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Харгалзан үзэх нотолгоонд тухайн тайлангийн өдрийн дараах үйл явдлуудын үр дүнд бий болсон аливаа нэмэлт нотолгоо хамаарна. Ийм нотолгоонд үндэслэн авч үзэхэд:
- (а) Тухайн тайлангийн өдрөөр одоогийн үүрэг оршин байх нь үл оршин байхаас илүү магадлалтай тохиолдолд уг байгууллага нь нөөцийг хүлээн зөвшөөрнө (хэрэв хүлээн зөвшөөрөлтийн шалгуур хангагдах бол);
  - (б) Тухайн тайлангийн өдрөөр одоогийн үүрэг оршин байхгүй гэдэг нь илүү их магадлалтай бол эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцийг зарцуулах магадлал маш бага байхаас бусад тохиолдолд байгууллага нь болзошгүй өр төлбөрийг тодруулна (100-р параграфыг үзнэ үү).

*Өнгөрсөн үйл явдал*

25. Одоогийн үүрэг үүсэхэд хүргэдэг өнгөрсөн үйл явдлыг үүрэг хүлээлгэх үйл явдал гэж нэрлэдэг. Үйл явдал нь үүрэг хүлээлгэх үйл явдал байхын тулд тухайн байгууллага нь уг үйл явдлаар үүсгэсэн үүргийг барагдуулахаас өөр бодит сонголтгүй байх ёстой. Ийм нөхцөл нь зөвхөн дараах тохиолдолд үүснэ:
- (а) Үүргийн барагдуулалтыг хуулиар хүчин төгөлдөр хэрэгжүүлж болох; эсвэл
  - (б) Гэрээний бус үүргийн хувьд тухайн үйл явдал (энэ нь байгууллагын үйлдэл байж болно) нь үүргийг уг байгууллага биелүүлнэ гэсэн бодит хүлээлтийг нөгөө талдаа үүсгэсэн байх.
26. Санхүүгийн тайлан нь ирээдүйн тайлант үе дэх санхүүгийн боломжит байдлыг биш, харин тухайн тайлант үеийн эцэс дэх уг байгууллагын санхүүгийн байдлыг илэрхийлдэг. Иймээс байгууллагын ирээдүйн тасралтгүй үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулахын тулд гаргах шаардлагатай өртөг зардлын хувьд нөөцийг хүлээн зөвшөөрөхгүй. Байгууллагын санхүүгийн байдлын тайланд зөвхөн хүлээн зөвшөөрөх өр төлбөр нь тухайн тайлангийн өдрөөр оршин байгаа өр төлбөр юм.
27. Өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн бөгөөд байгууллагын ирээдүйн үйлдлээс (өөрөөр хэлбэл, түүний үйл ажиллагааг ирээдүйд эрхлэн явуулалтаас) хамааралгүй байдлаар оршин буй зөвхөн тийм үүргийг нөөц гэж хүлээн зөвшөөрдөг. Ийм үүргийн жишээ нь; байгаль орчинд хууль бусаар учруулсан хор хөнөөлийн хувьд улсын секторын байгууллагад хууль тогтоомжоор хүлээлгэсэн торгууль буюу түүнийг арилгах зардал.



Эдгээр үүргийн аль аль нь тухайн улсын секторын байгууллагын ирээдүйн үйлдлээс үл хамааран тэдгээрийн барагдуулалтаар эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцийг зарцуулахад хүргэж болох юм. Үүнтэй адилаар, улсын секторын байгууллага нь батлан хамгаалах байгууламж буюу засгийн газрын өмчлөлт цөмийн эрчим хүчний станцыг татан буулгах зардлын хувьд уг байгууллага өөрийн аль хэдийн учруулсан хор хөнөөлийг арилгах үүрэг хүлээсэн хэмжээгээр нөөцийг хүлээн зөвшөөрнө. Тухайн хөрөнгийн өртөгт тусган оруулдаг зүйлсийг, үүн дотроо нураан буулгах ба газар талбайг цэвэрлэн хэвийн байдалд оруулах зардлыг УСНББОУС 17, *Үндсэн Хөрөнгө*-д авч үзсэн. Харин эсрэгээр, хуулийн шаардлага, оролцогчдын шахалт эсвэл нийгмийн манлайллаа харуулах хүсэл эрмэлзлийн улмаас байгууллага нь ирээдүйд тодорхой арга замаар үйл ажиллагаагаа явуулахын тулд зарлага гаргахаар төлөвлөсөн буюу ингэх шаардлагатай байж болох юм. Жишээлбэл; улсын секторын байгууллага нь зарим төрлийн үйлдвэрийн хувьд утаа шүүгч суурилуулахаар шийдвэрлэх эсвэл засгийн газрын лаборатори нь зарим химийн бодисын ууршилтаас ажилчдыг хамгаалахын тулд хий зайлуулах төхөөрөмж суурилуулахаар шийдвэрлэх. Байгууллага нь ирээдүйн үйлдлээрээ, тухайлбал, өөрийн үйл ажиллагааны аргыг өөрчилснөөр ийм ирээдүйн зарлагаас зайлсхийж болох тул тэрхүү ирээдүйн зарлагын хувьд одоогийн үүрэггүй бөгөөд иймээс нөөцийг хүлээн зөвшөөрөхгүй.

28. Үүрэг нь түүний биелэлтийг хүлээн авах нэг талыг ямагт агуулсан байдаг. Гэвч үүргийн гүйцэтгэлийг хүлээн авах талыг заавал тодорхойлох шаардлагагүй бөгөөд чухамдаа үүргийг нийт олон түмний өмнө хүлээсэн ч байж болох юм. Үүрэг нь нөгөө талын өмнө хүлээх хариуцлагыг ямагт агуулдаг учраас эндээс дараах гаргалгаа дүгнэлт хийнэ: байгууллагын удирдлага, удирдах зөвлөл буюу хяналт тавигч байгууллагын гаргасан шийдвэрийг уг байгууллага өөрийн хариуцлагаа биелүүлнэ гэсэн бодит хүлээлтийг нөгөө талдаа үүсгэхүйц тийм хангалттай тодорхой байдлаар тухайн тайлангийн өдрөөс өмнө тэрхүү нөгөө талд хүргэн танилцуулснаас бусад тохиолдолд тэдгээр шийдвэр нь уг тайлангийн өдрөөр гэрээний бус үүрэг үүсэхэд хүргэхгүй.
29. Үүргийг шууд үүсгэдэггүй үйл явдал нь хууль тогтоомжийн өөрчлөлт эсвэл гэрээний бус үүрэг үүсэхэд хүргэх уг байгууллагын үйлдлийн (жишээлбэл; олон нийтэд хийсэн тодорхой мэдэгдлийн) улмаас дараа нь үүрэг үүсэхэд хүргэж болох юм. Жишээлбэл; засгийн газрын агентлагаас байгаль орчинд хор хөнөөл учруулсан боловч түүний үр дагаврыг арилгах үүрэг хүлээдэггүй байж болох юм. Гэвч шинэ хууль нь одоо учруулсан байгаа хохирлыг арилгахыг шаардсан эсвэл тухайн хяналт тавигч засгийн газар болон бие даасан агентлаг нь хор хөнөөлийг арилгах хариуцлага хүлээхээ нийтийн өмнө хүлээн зөвшөөрснөөр гэрээний бус үүрэг үүссэн тохиолдолд тэрхүү хохирол учруулалт нь үүрэг хүлээлгэх үйл явдал болох юм.

30. Санал болгож буй шинэ хуулийн төслийг бүрэн эцэслээгүй байгаа тохиолдолд уг хууль нь төсөлд тусгасантай адилаар үйлчлэх нь үнэхээр тодорхой болсон зөвхөн тэр хэмжээгээр үүрэг үүснэ. Энэ Стандартын зорилгын хувьд ийм үүргийг хуулиар хүлээсэн үүрэг гэж үзнэ. Гэвч хуулийг батлах үеийн нөхцөл байдлын өөрчлөлт нь хуулийн үйлчлэл үнэхээр тодорхой болоход хүргэх зөвхөн нэг үйл явдлыг тусгайлан тодорхойлох боломжгүй болгож болох юм. Ихэнх тохиолдолд уг санал болгосон шинэ хууль нь төсөлд тусгасантай адилаар үйлчлэх эсэхийг шүүн тунгаах боломжгүй бөгөөд тэрхүү үүргийн оршин байдлын талаархи аливаа шийдвэр нь тухайн хууль эцэслэн батлагдах хүртэл хүлээх шаардлагатай байдаг.

*Эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцийн магадлалт зарцуулалт*

31. Өр төлбөр нь хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангахын тулд зөвхөн одоогийн үүрэгтэй байх төдийгүй уг үүргийг барагдуулахын тулд эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцийг зарцуулах магадлалтай байх ёстой. Хэрэв үйл явдал гарч тохиолдох нь үл тохиолдохоос илүү магадлалтай, өөрөөр хэлбэл тухайн үйл явдал тохиолдох магадлал нь үл тохиолдох магадлалаас өндөр байвал нөөцийн зарцуулалт буюу бусад үйл явдлыг энэ Стандартын зорилгын хувьд нилээд магадлалтай гэж үздэг. Одоогийн үүрэг оршин байх магадлалгүй бол эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцийг зарцуулах магадлал маш бага байхаас бусад тохиолдолд байгууллага нь болзошгүй өр төлбөрийг тодруулна (100-р параграфыг үзнэ үү).
32. Ижил төсөөтэй олон үүрэг (жишээлбэл; засгийн газрын өмчлөлт эмнэлгээс халдвартай цус авсан хувь хүмүүст нөхөн олговор олгох засгийн газрын үүрэг) байгаа тохиолдолд тухайн үүргийн ангийг бүхэлд нь авч үзсэнээр үүргийг барагдуулахад шаардлагатай зарлагын магадлалыг тодорхойлно. Аль нэг зүйлийн хувьд зарлага гаргах магадлал нь бага байж болох боловч тухайн ангийн үүргүүдийг бүхэлд нь барагдуулахын тулд зарим нөөцийг зарцуулах шаардлагатай гэдэг нь нилээд магадлалтай байж болно. Хэрэв ийм магадлалтай бол (хүлээн зөвшөөрөлтийн бусад шалгуур хангагдаж байвал) нөөцийг хүлээн зөвшөөрнө.

*Үүргийн найдвартай тооцоолол*

33. Тооцоолол ашиглах нь санхүүгийн тайлан бэлтгэлтийн чухал хэсэг боловч санхүүгийн тайлангийн найдвартай байдлыг бууруулахгүй. Ялангуяа, нөөц нь өөрийн шинж чанарын улмаас бусад ихэнх хөрөнгө буюу өр төлбөрөөс арай тодорхой бус байдаг тул тооцооллыг ихээр ашигладаг. Туйлын ховор тохиолдлоос бусад үед байгууллага нь боломжит үр дүнгүүдийн мужийг тодорхойлох боломжтой бөгөөд ингэснээр нөөцийг хүлээн зөвшөөрөхөд ашиглах үүргийн дүнг хангалттай найдвартайгаар тооцоолж чадах юм.

34. Найдвартай тооцоолол хийж чадахгүй туйлын ховор тохиолдолд хүлээн зөвшөөрөх боломжгүй тийм өр төлбөртэй байдаг. Ийм өр төлбөрийг болзошгүй өр төлбөр гэж тодруулна (100-р параграфыг үзнэ үү).

### **Болзошгүй өр төлбөр**

35. **Байгууллага нь болзошгүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй.**
36. Эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцийг зарцуулах магадлал нь бага байхаас бусад тохиолдолд 100-р параграфтаар шаардсанчлан, болзошгүй өр төлбөрийг тодруулна.
37. Байгууллага нь үүргийг хамтран болон хэд хэдээрээ хариуцдаг тохиолдолд бусад талуудын хариуцахаар хүлээгдэж буй үүргийн хэсгийг болзошгүй өр төлбөр гэж үзнэ. Жишээлбэл; хамтын хэлэлцээрийн өрийн хувьд, тухайн хамтын хэлэлцээрийн бусад оролцогчдын биелүүлэх үүргийн тэрхүү хэсгийг болзошгүй өр төлбөр гэж үздэг. Найдвартай тооцоолол хийж чадахгүй туйлын ховор тохиолдлоос бусад үед, байгууллага нь эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцийг зарцуулах нилээд магадлалтай үүргийн тэрхүү хэсгийн хувьд нөөцийг хүлээн зөвшөөрнө.
38. Болзошгүй өр төлбөр нь анх хүлээгдэж байснаас өөр байдлаар үүсэж болох юм. Иймээс эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадвахи бүхий нөөцийг зарцуулах нилээд магадлалтай болсон эсэхийг тодорхойлохын тулд болзошгүй өр төлбөрийг байнга үнэлнэ. Хэрэв өмнө нь болзошгүй өр төлбөр гэж үзэж байсан зүйлийн хувьд ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг зарцуулах нилээд магадлалтай болвол (найдвартай тооцоолол хийх боломжгүй туйлын ховор тохиолдлоос бусад үед) уг магадлал өөрчлөгдсөн тайлант үеийн санхүүгийн тайланд нөөцийг хүлээн зөвшөөрнө. Жишээлбэл; орон нутгийн засаг захиргааны байгууллага нь байгаль орчны хуулийг зөрчсөн боловч байгаль орчинд ямар нэг хохирол учирсан эсэх нь тодорхойгүй байж болох юм. Харин хохирол учирсан бөгөөд нөхөн сэргээх шаардлагатай гэдэг нь дараа тодорхой болсон тохиолдолд эдийн засгийн үр өгөөжийг зарцуулах нь одоо нилээд магадлалтай учраас тухайн байгууллага нөөцийг хүлээн зөвшөөрнө.

### **Болзошгүй хөрөнгө**

39. **Байгууллага нь болзошгүй хөрөнгийг хүлээн зөвшөөрөхгүй.**
40. Болзошгүй хөрөнгө нь (а) тухайн байгууллагын хяналтанд бүхэлдээ байдаггүй, (б) тухайн байгууллагад эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи авчрах боломжийг бий болгох тийм төлөвлөөгүй буюу бусад байдлаар хүлээгдээгүй үйл явдлаас ихэвчлэн үүсдэг. Жишээлбэл; үр дүн нь тодорхойгүй хуулийн процессын дагуу тухайн байгууллагын гаргасан нэхэмжлэл.

41. Болзошгүй хөрөнгө нь хэзээ ч хэрэгжихгүй байж болох орлогын хүлээн зөвшөөрөлтөнд хүргэж болох учраас түүнийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөхгүй. Харин орлогын хэрэгжилт нь үнэхээр тодорхой байгаа тохиолдолд холбогдох хөрөнгө нь болзошгүй хөрөнгө биш бөгөөд түүнийг хүлээн зөвшөөрөх нь зохистой юм.
42. Эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи орох нь нилээд магадлалтай тохиолдолд 105-р параграфтаар шаардсанчлан, болзошгүй хөрөнгийг тодруулна.
43. Нөхцөл байдлын өөрчлөлтийг санхүүгийн тайланд зохих ёсоор тусгасан гэдгийг ханган магадлахын тулд болзошгүй хөрөнгийг байнга үнэлнэ. Эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи орох нь үнэхээр тодорхой болсон ба хөрөнгийн үнэ цэнийг найдвартай хэмжиж чадах бол тухайн хөрөнгө болон холбогдох орлогыг уг өөрчлөлт гарч тохиолдсон тайлант үеийн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи орох нь нилээд магадлалтай болвол байгууллага нь уг болзошгүй хөрөнгийг тодруулна (105-р параграфыг үзнэ үү).

## **Хэмжилт**

### **Хамгийн сайн тооцоолол**

44. **Нөөц гэж хүлээн зөвшөөрсөн дүн нь тухайн тайлангийн өдрөөр уг одоогийн үүргийг барагдуулахад шаардлагатай зарлагын хамгийн сайн тооцоолол байвал зохино.**
45. Одоогийн үүргийг барагдуулахад шаардлагатай зарлагын хамгийн сайн тооцоолол нь тайлангийн өдрөөр уг үүргийг барагдуулах эсвэл тухайн хугацаанд түүнийг гуравдагч талд шилжүүлэхийн тулд байгууллагын зохих ёсоор төлөх дүн юм. Тухайн тайлангийн өдрөөр үүргийг барагдуулах буюу шилжүүлэх нь ихэвчлэн боломжгүй эсвэл хэт өндөр зардалтай байдаг. Гэхдээ уг үүргийг барагдуулах буюу шилжүүлэхийн тулд байгууллагын зохих ёсоор төлөх дүнгийн тооцоолол нь тухайн тайлангийн өдрөөрх тэрхүү одоогийн үүргийг барагдуулахад шаардлагатай зарлагын хамгийн сайн тооцооллыг илэрхийлдэг.
46. Тодорхойгүй байдлын үр дүн болон түүний санхүүгийн үр нөлөөний талаархи тооцооллыг тухайн байгууллагын удирдлагын шүүн тунгаалтаар тодорхойлж, ижил төсөөтэй ажил гүйлгээний талаархи туршлага, түүнчлэн зарим тохиолдолд хараат бус шинжээчдийн тайлангаар баталгаажуулдаг. Харгалзан үзэх нотолгоонд тухайн тайлангийн өдрийн дараах үйл явдлын үр дүнд бий болсон аливаа нэмэлт нотолгоо хамаарна.

*Жишээ*

Улсын эмнэлгийн лаборатори нь хэт авианы оношилгооны төхөөрөмжийг төрийн өмчит ба хувийн хэвшлийн эрүүл мэндийн төвүүд болон эмнэлгүүдэд өртгийг бүрэн нөхөх үнээр нийлүүлдэг. Худалдан авалтын дараах эхний 6 сарын дотор илэрсэн аливаа доголдол гэмтлийн засварын зардлыг тэдгээр эрүүл мэндийн төвүүд болон эмнэлгүүдэд нөхөн олгох баталгаатайгаар уг тоног төхөөрөмжийг нийлүүлсэн. Нийлүүлсэн бүх тоног төхөөрөмжинд жижиг доголдол гэмтэл илэрвэл 1 сая мөнгөн нэгжийн засварын зардал гарах юм. Хэрэв нийлүүлсэн бүх тоног төхөөрөмжинд томоохон доголдол гэмтэл илэрвэл 4 сая мөнгөн нэгжийн засварын зардал гарна. Лабораторийн өнгөрсөн туршлага ба ирээдүйн хүлээлтээс харахад, ирэх жил тэдгээр тоног төхөөрөмжийн 75 хувь нь ямар нэг доголдол гэмтэлгүй, 20 хувь нь жижиг доголдол гэмтэлтэй, үлдсэн 5 хувь нь томоохон доголдол гэмтэлтэй байх юм. 32-р параграфт заасанчлан, тус лаборатори нь нийт баталгааны үүргийн хувьд зарлагын магадлалыг үнэлнэ.

Засварын зардлын хүлээгдэж буй дүн нь:

$$(0\text{-ийн } 75\%)+(1\text{ саяын } 20\%)+(4\text{ саяын } 5\%)=400,000$$

47. Нөөц гэж хүлээн зөвшөөрөх дүнгийн талаархи тодорхой бус байдлыг тухайн нөхцөл байдалд тохирох янз бүрийн арга хэрэгслээр авч үздэг. Хэмжиж буй нөөц нь том олонлогийг хамрах тохиолдолд бүх боломжит үр дүнгүүдийг тэдгээрийн холбогдох магадлалаар жинэлснээр уг үүргийг тооцоолно. Энэхүү статистик тооцооллын аргыг “хүлээгдэж буй үнэ цэнэ” гэж нэрлэдэг. Иймээс нөөц нь тухайн гарзны дүнгийн магадлал хэд байхаас, жишээлбэл; 60 хувь эсвэл 90 хувь гэдгээс хамааран өөр өөр байна. Боломжит үр дүнгүүд бүхий тасралтгүй мужтай бөгөөд мужийн доторх цэг бүр нь аливаа бусад цэгүүдтэй ижил магадлалтай байх тохиолдолд тухайн мужийн дундаж цэгийг ашиглана.
48. Нэг үүргийг хэмжиж байгаа тохиолдолд тухайн хамгийн магадлалтай үр дүн нь уг өр төлбөрийн хамгийн сайн тооцоолол байж болох юм. Гэхдээ байгууллага нь ийм тохиолдолд ч гэсэн бусад боломжит үр дүнгүүдийг харгалзан үзнэ. Бусад боломжит үр дүнгүүд нь хамгийн магадлалтай үр дүнгээс ихэвчлэн өндөр эсвэл ихэвчлэн бага байх тохиолдолд хамгийн сайн тооцоолол нь арай өндөр эсвэл арай бага дүн байх юм. Жишээлбэл; засгийн газар нь өөр нэг засгийн газарт зориулан барьж өгсөн цэргийн усан онгоцныхоо ноцтой гэмтлийг засах үүрэгтэй бол хамгийн магадлалтай нэг үр дүн нь уг засварын хувьд эхний удаад 100,000 мөнгөн нэгжийн зардал гаргахаар байж болох боловч дахин засварлах шаардлагатай гэдэг нь мэдэгдэхүйц магадлалтай бол тэрхүү арай том зардлын хувьд нөөц байгуулна.

49. Нөөцийн татвар буюу татвартай адилтгах төлбөрийн өмнөх дүнгээр хэмжинэ. Нөөцийн татварын үр дагавар болон түүний өөрчлөлтийн талаархи заавар удирдамжийг НББОУС 12-оос үзэж болно.

**Эрсдэл ба тодорхой бус байдал**

50. **Олон үйл явдал ба нөхцөл байдлын хүрээнд зайлшгүй оршин байдаг эрсдэл болон тодорхой бус байдлыг уг нөөцийн хамгийн сайн тооцооллыг хийхдээ харгалзан үзнэ.**
51. Эрсдэл нь үр дүнгийн хувьсан өөрчлөлтийг тодорхойлдог. Эрсдлийн тохируулга нь өр төлбөрийг хэмжих дүнг нэмэгдүүлж болох юм. Орлого буюу хөрөнгийг илүү илэрхийлэхгүй, харин зардал буюу өр төлбөрийг дутуу илэрхийлэхгүй байхын тулд тодорхой бус нөхцөл байдалд шүүн тунгаалт хийхдээ хянуур хандах шаардлагатай. Гэхдээ тодорхой бус байдал нь хэт их нөөц үүсгэх эсвэл өр төлбөрийг зориудаар илүү илэрхийлэхийг зөвтгөх үндэслэл болохгүй. Жишээлбэл; тухайн нэг сөрөг үр дагаврын төсөвлөсөн зардлыг хэт болгоомжилсон сууриар, илүү дүнгээр тооцоолвол тэрхүү үр дүнг уг бодит байдлаас илүү магадлалтай гэж зориуд худлаа илэрхийлж болохгүй. Эрсдэл болон тодорхой бус байдлын тохируулгыг давхардуулж тооцох, ингэснээр нөөцийг илүү тооцохгүй байхад анхаарал хандуулах хэрэгтэй.
52. Зарлагын дүнтэй холбоотой тодорхой бус байдлыг 98(б) параграфын дагуу тодруулна.

**Өнөөгийн үнэ цэнэ**

53. **Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ нь материаллаг нөлөөтэй байх тохиолдолд нөөцийн дүн нь уг үүргийг барагдуулахад шаардагдахаар хүлээгдэж буй зарлагын өнөөгийн үнэ цэнэ байна.**
54. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнээс хамааран тухайн тайлангийн өдрийн дараахан гарсан мөнгөн зарлагын холбогдох нөөц нь арай сүүлд гарсан ижил дүн бүхий мөнгөн зарлагад хамаарах нөөцөөс илүү буруу байх магадлалтай байдаг. Иймээс энэхүү үр нөлөө нь материаллаг байх тохиолдолд нөөцийг дискаунтчилна.
- Нөөцийг олон жилээр дискаунтчилсан тохиолдолд уг нөөц нь тухайн барагдуулахаар хүлээгдэж буй хугацаанд ойртохын хирээр нөөцийн өнөөгийн үнэ цэнэ нь жил бүр нэмэгддэг (Үлгэрчилсэн жишээг үзнэ үү).
55. Цаг хугацаа урсан өнгөрснөөр энэхүү дискаунтчилсан дүнд тухайн тайлант үеийн туршид үүсэх нэмэгдэлтийг тодруулахыг энэхүү Стандартын 97(д) параграфээр шаардсан байдаг.
56. **Дискаунтын хувь (эсвэл хувиуд) нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн талаархи одоогийн зах зээлийн үнэлгээ болон уг өр төлбөрт тусгайлан хамаарах эрсдлийг тусгасан, татварын өмнөх хувь хэмжээ (буюу хувь хэмжээнүүд) байна. Дискаунтын хувь хэмжээ (хувь**

**хэмжээнүүд) нь тухайн эрсдлийн хувьд ирээдүйн мөнгөн гүйлгээний тооцооллыг тохируулсан тийм эрсдлийг тусган илэрхийлэхгүй.**

57. Зарим улс оронд улсын секторын байгууллагын тухайн тайлант үеийн ашигт орлогын албан татвар буюу орлогын албан татвартай адилтгах татварыг ногдуулдаг. Улсын секторын байгууллагуудад ийм орлогын албан татвар ногдуулдаг тохиолдолд уг сонгох дискаунтын хувь хэмжээ нь татварын өмнөх хувь хэмжээ байна.

#### **Ирээдүйн үйл явдлууд**

58. **Үүргийг барагдуулахад шаардагдах дүнд нөлөөлж болох ирээдүйн үйл явдлууд нь гарч тохиолдоно гэсэн хангалттай, бодитой нотолгоо байгаа тохиолдолд уг ирээдүйн үйл явдлуудыг нөөцийн дүнд тусгана.**
59. Хүлээгдэж буй ирээдүйн үйл явдлууд нь нөөцийг хэмжихэд чухал ач холбогдолтой байж болно. Жишээлбэл; төлбөр хүлээн авагчдад инфляци буюу үнийн бусад тусгай өөрчлөлтийн үр нөлөөний хувьд нөхөн төлбөр олгохын тулд зарим өр төлбөрийг индексжүүлсэн байж болно. Хэрэв инфляцийн хүлээгдэж буй магадлалт хувь хэмжээний талаар хангалттай нотолгоо байгаа бол үүнийг нөөцийн дүнд тусгах хэрэгтэй. Нөөцийн дүнд нөлөөлөх ирээдүйн үйл явдлуудын өөр нэг жишээг дурдвал; хийн үйлдвэрийн талбартай холбоотой давирхай, үнс болон бусад бохирдлыг түүний ашиглалтын хугацааны эцэст цэвэрлэх өртөг зардлыг технологийн ирээдүйн өөрчлөлтөөр бууруулна гэж Засгийн газар найдаж байна. Энэ тохиолдолд уг хүлээн зөвшөөрөх дүн нь тухайн цэвэрлэн сэргээх үед ашиглагдах боломжтой болох технологийн талаархи бүх боломжит нотолгоог харгалзан үзсэн техникийн мэргэшсэн, хараат бус экспертийн гарна гэж ул үндэслэлтэйгээр хүлээж буй өртөг зардлыг тусгана. Иймээс нөөцөд тухайлбал дараах зүйлсийг харгалзан тусгах хэрэгтэй. Үүнд: одоогийн технологийг хэрэглэх талаархи туршлага нэмэгдсэнтэй холбоотой хүлээгдэж буй зардлын бууралт эсвэл өмнө хийж байснаас илүү том, нарийн цогц цэвэрлэгээний үйл ажиллагаанд одоогийн технологийг хэрэглэсэнтэй холбоотой хүлээгдэж буй зардлын бууралт хамаарна. Гэхдээ хангалттай, бодит нотолгоогоор дэмжигдэн батлагдсанаас бусад тохиолдолд байгууллага нь ийм цэвэрлэн сэргээх цоо шинэ технологийн дэвшлийг урьдчилан төсөөлөн тусгахгүй.
60. Уг хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчлэх нь үнэхээр тодорхой гэсэн хангалттай, бодитой нотолгоо байгаа тохиолдолд засгийн газрын буюу улсын секторын бие даасан байгууллагын одоогийн үүргийн дүнд нөлөөлж болох боломжит шинэ хууль тогтоомжийн үр нөлөөг тэрхүү үүргийг хэмжихдээ харгалзан үзнэ. Практикт үүсэх янз бүрийн нөхцөл байдлууд нь тохиолдол тус бүрд хангалттай, бодитой нотолгоогоор хангах зөвхөн нэг үйл явдлыг тусгайлан тодорхойлох боломжгүй болгож болох юм. Тухайн хууль тогтоомж нь (а) ямар шаардлага тавих, ба (б) хүчин төгөлдөр болж, зохих ёсоор хэрэгжих нь үнэхээр тодорхой эсэх талаархи

нотолгоо шаардлагатай байдаг. Ихэнх тохиолдолд шинэ хууль тогтоомж эцэслэн батлагдах хүртэл хангалттай, бодитой нотолгоо бэлэн байдаггүй.

### **Хөрөнгийн хүлээгдэж буй данснаас хасалт**

61. **Хөрөнгийн хүлээгдэж буй данснаас хасалтаас үүсэх олзыг нөөцийн хэмжилтэнд харгалзан үзэхгүй.**
62. Хүлээгдэж буй данснаас хасалт нь тухайн нөөцийг үүсгэхэд хүргэсэн үйл явдалтай нягт холбоотой байлаа ч гэсэн хөрөнгүүдийн хүлээгдэж буй данснаас хасалтын олзыг нөөцийн хэмжилтэнд харгалзан үзэхгүй. Харин байгууллага нь тухайн хөрөнгөтэй холбоотой УСНББОУС-аар тусгайлан заасан хугацаанд түүний хүлээгдэж буй данснаас хасалтын олзыг хүлээн зөвшөөрнө.

### **Нөхөн төлбөр**

63. **Нөөцийг барагдуулахад шаардлагатай бүх буюу зарим зарлагыг өөр нэг тал нөхөн төлөхөөр хүлээгдэж байгаа үед тухайн байгууллага нь уг үүргийг барагдуулвал нөхөн төлбөрийг хүлээн авна гэдэг нь үнэхээр тодорхой байх зөвхөн тийм тохиолдолд нөхөн төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Нөхөн төлбөрийг тусдаа хөрөнгө байдлаар авч үзнэ. Нөхөн төлбөр байдлаар хүлээн зөвшөөрөх дүн нь нөөцийн дүнгээс илүүгүй байна.**
64. **Нөөцтэй холбоотой зардлыг уг нөхөн төлбөрийн хувьд хүлээн зөвшөөрсөн дүнг хассан цэвэр дүнгээр санхүүгийн үр дүнгийн тайланд толилуулж болно.**
65. Зарим үед байгууллага нь нөөцийг барагдуулахад шаардлагатай зарлагын бүх буюу зарим хэсгийг өөр нэг этгээдээр төлүүлэхээр (жишээлбэл; даатгалын гэрээ, хохирлыг барагдуулах заалт, бэлтгэн нийлүүлэгчдийн баталгааны үр дүнд) хандаж болох юм. Уг өөр тал нь тухайн байгууллагын төлсөн дүнг нөхөн олгох эсвэл тэрхүү дүнг шууд төлж болно. Жишээлбэл; засгийн газрын агентлаг нь түүний ажилтнуудын өгсөн алдаатай зөвлөмжийн улмаас хувь хүний өмнө хуулийн хариуцлага хүлээсэн байж болно. Гэвч тухайн агентлаг нь ийм зарлагын зарим хэсгийг мэргэжлийн хариуцлагын даатгалаар нөхөн төлүүлэх боломжтой байж болох юм.
66. Хэрэв гуравдагч тал нь ямар нэг шалтгааны улмаас төлбөрийг төлөхгүй бол байгууллага уг дүнг бүхэлд нь барагдуулах шаардлагатай болох учраас тухайн байгууллага нь ихэнх тохиолдолд тэрхүү харгалзан үзэж буй дүнг бүхэлд нь хариуцсан хэвээр байна. Ийм нөхцөл байдалд, өр төлбөрийн нийт дүнгээр нөөцийг хүлээн зөвшөөрөх бөгөөд байгууллага нь уг өр төлбөрийг барагдуулвал нөхөн төлбөр хүлээн авна гэдэг нь үнэхээр тодорхой болсон үед тэрхүү хүлээгдэж буй нөхөн төлбөрийн хувьд тусдаа хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.



67. Гуравдагч тал нь төлбөрийг төлөөгүй зарим тохиолдолд уг байгууллага нь тухайн харгалзан үзэж буй зардлыг хариуцан төлдөггүй. Ийм тохиолдолд уг байгууллага нь тэдгээр зардалтай холбоотой өр төлбөрийг хариуцахгүй бөгөөд нөөцийн дүнд түүнийг оруулан тусгахгүй.
68. 37-р параграфт заасанчлан, байгууллагын хамтран болон хэд хэдээрээ хариуцдаг үүрэг нь бусад талуудын хариуцан барагдуулахаар хүлээгдэж буй тэр хэмжээгээр болзошгүй өр төлбөр болдог.

### **Нөөцийн өөрчлөлт**

69. **Нөөцийг тайлангийн өдөр нэг бүрээр нягталж шалгах бөгөөд одоогийн хамгийн сайн тооцооллыг тусгахын тулд түүнийг тохируулна. Хэрэв үүргийг барагдуулахад шаардагдах эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцийг зарцуулах магадлал цаашид үгүй болвол уг нөөцийг буцаана.**
70. Дискаунтчлал ашигладаг тохиолдолд нөөцийн дансны үнэ нь цаг хугацаа урсан өнгөрөлтийг тусгахын тулд тайлант үе бүрд нэмэгддэг. Энэхүү нэмэгдэлтийг хүүний зардал гэж хүлээн зөвшөөрнө.

### **Нөөцийн ашиглалт**

71. **Тодорхой зарлагад зориулж, анхнаасаа хүлээн зөвшөөрсөн нөөцийг зөвхөн тэрхүү зарлагын хувьд ашиглана.**
72. Анхнаасаа зориулан байгуулсан нөөцөд хамааралтай зөвхөн тийм зарлагыг уг нөөцөөс хаана. Анхнаасаа өөр зорилгоор хүлээн зөвшөөрч, байгуулсан нөөцөөс зарлагыг хаах нь хоёр өөр үйл явдлын үр нөлөөг нуун далдлахад хүргэдэг.

### **Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийн дүрмүүдийг мөрдөх**

#### **Ирээдүйн үйл ажиллагааны цэвэр алдагдал**

73. **Ирээдүйн үйл ажиллагаанаас үүсэх цэвэр алдагдлын хувьд нөөц хүлээн зөвшөөрөхгүй.**
74. Ирээдүйн үйл ажиллагаанаас үүсэх цэвэр алдагдал нь 18-р параграф дахь өр төлбөрийн тодорхойлолт болон нөөцийн хувьд 22-р параграфт заасан хүлээн зөвшөөрөлтийн ерөнхий шалгуурыг хангадаггүй.
75. Ирээдүйн ажиллагаанаас үүсэх цэвэр алдагдлын хүлээлт нь тухайн үйл ажиллагаанд ашиглагдаж буй зарим хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болохыг илэрхийлэх шинж тэмдэг юм. Байгууллага нь тэдгээр хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэхийг сорьж шалгана. Үнэ цэнийн бууралтыг тайлагнах талаархи заавар удирдамжийг УСНББОУС 21, *Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт* эсвэл УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-ын аль тохиромжтойгоос үзэж болно.

### **Алдагдалтай гэрээ**

76. **Хэрэв байгууллага нь алдагдалтай гэрээ байгуулсан бол уг гэрээний дагуу хүлээх одоогийн үүргийг (нөхөн төлбөрийг хассан цэвэр дүнг) нөөц гэж хүлээн зөвшөөрч, хэмжинэ.**
77. Энэ Стандартын 76-р параграфыг зөвхөн алдагдалтай гэрээний хувьд мөрдөнө. Нийлүүлсэн бараа, үйлчилгээнийхээ үнэ цэнэтэй ойролцоогоор тэнцүү төлбөрийг байгууллага нь тэдгээр үр өгөөж хүртэгчдээс хариу болгон шууд хүлээн авахгүй гэсэн хүлээлттэйгээр байгуулсан, нийгмийн халамж үзүүлэх гэрээ нь энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй.
78. Арилжааны ажил гүйлгээг нотлон илэрхийлэх олон гэрээг (жишээлбэл, зарим ердийн худалдан авалтын захиалга) нөгөө талдаа нөхөн төлбөр төлөхгүйгээр цуцалж болдог тул үүрэг хүлээхгүй. Өөр зарим гэрээ нь гэрээлэгч талууд тус бүрийн эрх ба үүргийн аль алиныг заасан байдаг. Хэрэв үйл явдлын үр дүнд ийм гэрээ нь алдагдалтай болвол уг гэрээ нь энэ Стандартын цар хүрээнд хамаарах бөгөөд хүлээн зөвшөөрөх өр төлбөр үүснэ. Бүрэн биелэгдээгүй гэрээ нь алдагдалтай биш бол энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй.
79. Гэрээний үүргийг биелүүлэхэд гарах зайлсхийх боломжгүй зардал нь уг гэрээний дагуу авахаар хүлээгдэж буй эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхиас, үүн дотроо нөхөгдөх дүнгүүдээс хэтрэх гэрээ гэж алдагдалтай гэрээг энэ Стандартад тодорхойлдог. Иймээс энэ нь 76-р параграфын дагуу нөөц гэж хүлээн зөвшөөрөх ба нөхөн төлбөрийг хассан цэвэр, одоогийн үүрэг байна. Гэрээний дагуу гарах зайлсхийх боломжгүй зардал нь тухайн гэрээг дуусгавар болгох хамгийн бага цэвэр зардлыг илэрхийлдэг. Хамгийн бага цэвэр зардал нь гэрээг биелүүлэх зардал ба гэрээг үл биелүүлснээс үүсэх нөхөн төлбөр, торгуулийн аль бага дүн юм.
80. Алдагдалтай гэрээний хувьд тусдаа нөөц байгуулахын өмнө, байгууллага нь тухайн гэрээнд зориулан ашиглах хөрөнгийн хувьд гарсан аливаа үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрнө.

### **Бүтцийн өөрчлөлт**

81. Бүтцийн өөрчлөлт гэсэн тодорхойлолтонд хамаарч болох үйл явдлуудын жишээг доор харуулав:
- (а) Үйл ажиллагаа болон үйлчилгээний дуусгавар болголт буюу данснаас хасалт;
  - (б) Тодорхой байршил буюу бүс нутаг дахь салбарыг хаах эсвэл засгийн газрын агентлагийн үйл ажиллагааг дуусгавар болгох, эсвэл үйл ажиллагааг нэг бүс нутгаас өөр бүс нутагт шилжүүлэн байршуулах;
  - (в) Удирдлагын бүтцийн өөрчлөлт, жишээлбэл; удирдлагын буюу гүйцэтгэх үйлчилгээний нэг шатлалыг үгүй болгох; ба

- (г) Байгууллагын үйл ажиллагааны шинж төрөл ба чиглэлд материаллаг нөлөө үзүүлэхүйц томоохон дахин зохион байгуулалт.
82. 22-р параграфт заасан нөөцийн хүлээн зөвшөөрөлтийн ерөнхий шалгуур хангагдсан зөвхөн тийм тохиолдолд бүтцийн өөрчлөлтийн хувьд нөөцийг хүлээн зөвшөөрнө. Бүтцийн өөрчлөлтийн хувьд уг хүлээн зөвшөөрөлтийн ерөнхий шалгуурыг хэрхэн мөрдөхийг 83-96-р параграфт заасан.
83. **Бүтцийн өөрчлөлт хийх гэрээний бус үүрэг нь зөвхөн дараах тохиолдолд үүсдэг:**
- (a) **Байгууллага наад зах нь доорх зүйлсийг тодорхойлсон, бүтцийн өөрчлөлт хийх албан ёсны дэлгэрэнгүй төлөвлөгөөтэй байх:**
- (i) **Тухайн авч үзэж буй үйл ажиллагаа/үйл ажиллагааны нэгж буюу үйл ажиллагаа/үйл ажиллагааны нэгжийн нэг хэсэг;**
  - (ii) **Нөлөөнд өртөх үндсэн байршлууд;**
  - (iii) **Ажлаас халснаар нөхөн төлбөр олгох ажилтнуудын байршил, гүйцэтгэдэг үүрэг ба ойролцоо тоо;**
  - (iv) **Гарах зарлага; ба**
  - (v) **Төлөвлөгөөг хэзээ хэрэгжүүлэх эсэх;**
- (б) **Байгууллага нь тухайн төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлснээр эсвэл түүний гол шинжүүдийг холбогдох хүмүүст мэдэгдсэнээр бүтцийн өөрчлөлт хийгдэнэ гэсэн бодит хүлээлтийг тэдгээр хамаарах талуудад үүсгэсэн байх.**
84. Улсын секторын хувьд бүтцийн өөрчлөлтийг нийт засгийн газрын түвшинд, багц буюу яамдын түвшинд эсвэл агентлагийн түвшинд хийж болно.
85. Засгийн газар буюу бие даасан байгууллага нь бүтцийн өөрчлөлт хийх төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлсэн гэдэг нь тухайлбал, (а) уг төлөвлөгөөний гол шинжүүдийг олон нийтэд зарлан мэдэгдсэнээр, (б) хөрөнгийг борлуулах буюу шилжүүлснээр, (в) түрээсийг цуцлах саналыг илэрхийлснээр, (г) үйлчилгээний харилцагчдын хувьд өөр гэрээ хэлцлийг байгуулснаар нотлогддог. Тухайн засгийн газар буюу байгууллага нь бүтцийн өөрчлөлт хийнэ гэсэн бодит хүлээлтийг үйлчилгээний хэрэглэгчид, бэлтгэн нийлүүлэгчид, ажилтнууд (эсвэл тэдний төлөөлөгчдөд) гэх мэт бусад талуудад төрүүлэхүйц тийм арга замаар, хангалттай дэлгэрэнгүй байдлаар танилцуулан мэдэгдсэн (өөрөөр хэлбэл, төлөвлөгөөний гол шинжүүдийг заасан) зөвхөн тийм тохиолдолд бүтцийн өөрчлөлт хийх дэлгэрэнгүй төлөвлөгөөг олон нийтэд зарлан мэдэгдэлт нь бүтцийн өөрчлөлт хийх гэрээний бус үүргийг бий болгоно.
86. Тухайн төлөвлөгөө нь гэрээний бус үүрэг үүсгэх хангалттай үндэслэлтэй байхын тулд холбогдох талуудад түүнийг танилцуулан мэдэгдэх үед уг төлөвлөгөөний хэрэгжилтийг нэн даруй эхлэх ба тэрхүү төлөвлөгөөнд

мэдэгдэхүйц өөрчлөлт оруулах боломжгүй тийм хугацаанд дуусгахаар төлөвлөгдсөн байх шаардлагатай. Хэрэв бүтцийн өөрчлөлтийг эхлэх хүртэл удахаар эсвэл бүтцийн өөрчлөлтийг хэтэрхий урт хугацаанд хийхээр хүлээгдэж байвал ийм урт хугацаа нь өөрийн төлөвлөгөөг өөрчлөх боломжийг тухайн засгийн газар буюу бие даасан байгууллагад олгох боломжтой учраас тэрхүү засгийн газар буюу бие даасан байгууллага бүтцийн өөрчлөлт хийх одоогийн үүрэгтэй гэсэн бодит хүлээлтийг бусад талуудад уг төлөвлөгөөгөөр үүсгэх магадлал багатай байдаг.

87. Байгууллага нь тайлангийн өдрөөс өмнө дараах үйлдлийг хийснээс бусад тохиолдолд бүтцийн өөрчлөлт хийхийн тулд тухайн тайлангийн өдрөөс өмнө гаргасан удирдлагын буюу удирдах зөвлөлийн шийдвэр нь тэрхүү тайлангийн өдрөөр гэрээний бус үүрэг үүсгэхгүй:

(а) Бүтцийн өөрчлөлт хийх төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлсэн; эсвэл

(б) Байгууллага нь бүтцийн өөрчлөлт хийнэ гэсэн бодит хүлээлтийг тэдгээр талуудад үүсгэхүйц тийм хангалттай тодорхой байдлаар уг бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөний гол шинжүүдийг түүнд хамаарах талуудад хүргэн танилцуулсан.

Хэрэв байгууллага нь зөвхөн тухайн тайлангийн өдрийн дараа уг бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлсэн эсвэл түүний гол шинжүүдийг холбогдох талуудад зарлан мэдэгдсэн бол тэрхүү бүтцийн өөрчлөлт нь материаллаг нөлөөтэй бөгөөд түүнийг үл тодруулах нь санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөө үзүүлэхээр байх тохиолдолд УСНББОУС 14, *Тайлангийн Өдрийн Дараах Үйл Явдал*-ын дагуу тодруулга хийх шаардлагатай байж болно.

88. Гэрээний бус үүрэг нь зөвхөн удирдлагын буюу удирдах зөвлөлийн шийдвэрээр үүсээд байдаггүй боловч ийм шийдвэр бүхий өмнөх бусад үйл явдлын үр дүнд гэрээний бус үүрэг үүсэж болно. Жишээлбэл; ажлаас халагдалтын төлбөрийн талаар ажилтнуудын төлөөлөгчидтэй, эсвэл үйл ажиллагааг борлуулах буюу шилжүүлэх талаар худалдан авагчидтай зөвхөн удирдах зөвлөл буюу төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрлийн дагуу хэлцэл хийж болох юм. Ийм зөвшөөрлийг авч, бусад талуудад хүргэн танилцуулмагц тухайн байгууллага нь хэрэв 83-р параграфт заасан нөхцөл хангагдаж байвал бүтцийн өөрчлөлтийн хувьд гэрээний бус үүрэг хүлээнэ.

89. Зарим улс оронд (а) улсын секторын байгууллагын талаар шийдвэр гаргах эцсийн бүрэн эрх нь удирдлагын ашиг сонирхлоос өөр ашиг сонирхолтой төлөөлөгчид (жишээлбэл; ажилчид) бүхий гишүүнчлэлтэй тийм удирдах зөвлөл буюу төлөөлөн удирдах зөвлөлөөр баталгааждаг, эсвэл (б) удирдах зөвлөл буюу төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг гаргахаас өмнө тэдгээр төлөөлөгчдөд мэдэгдэх шаардлагатай байж болно. Ийм удирдах зөвлөл буюу төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийг

тэдгээр бусад төлөөлөгчдөд хүргэн танилцуулдаг учраас энэ нь бүтцийн өөрчлөлт хийх гэрээний бус үүргийг үүсгэж болно.

*Үйл ажиллагааны борлуулалт буюу шилжүүлэлт*

90. **Байгууллага нь үйл ажиллагааг борлуулах буюу шилжүүлэх үүрэг хариуцлагатай болох, өөрөөр хэлбэл хууль ёсны хүчин төгөлдөр гэрээ байгуулах хүртэл тэрхүү үйл ажиллагааны борлуулалт буюу шилжүүлэлтийн үр дагавар байдлаар үүрэг үүсэхгүй.**
91. Хэдийгээр байгууллага нь үйл ажиллагааг борлуулах шийдвэрийг гаргаж, уг шийдвэрээ олон нийтэд зарлан мэдэгдсэн боловч худалдан авагчийг олж тогтоох ба хууль ёсны хүчин төгөлдөр борлуулалтын гэрээ байгуулах хүртэл уг борлуулалтын хувьд үүрэг хариуцлага үүсэхгүй. Хууль ёсны хүчин төгөлдөр борлуулалтын гэрээг байгуулах хүртэл уг байгууллага нь өөрийн шийдвэрийг өөрчилж болох бөгөөд хүлээн зөвшөөрөхүйц нөхцөл бүхий худалдан авагчийг олоогүй бол ямар ч маргаангүйгээр өөр арга хэмжээ авч болно. Борлуулалт нь бүтцийн өөрчлөлтийн зөвхөн нэг хэсэг байх тохиолдолд хууль ёсны хүчин төгөлдөр борлуулалтын гэрээг байгуулахаас өмнө тухайн бүтцийн өөрчлөлтийн бусад хэсгүүдийн хувьд гэрээний бус үүрэг үүсэж болно.
92. Улсын секторын хүрэн дэх бүтцийн өөрчлөлт нь хяналтанд буй нэг байгууллагаас хяналтанд буй нөгөө байгууллагад хийгдэх үйл ажиллагааны шилжүүлэлтийг ямагт агуулдаг бөгөөд үүнд үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр хийгдэх үйл ажиллагааны шилжүүлэлт хамаарч болох юм. Ийм шилжүүлэлт нь ихэвчлэн засгийн газрын удирдамж чиглэлийн дагуу хийгдэх бөгөөд 90-р параграфт дурдсанчлан, хууль ёсны хүчин төгөлдөр гэрээгүй байж болно. Шилжүүлэлтийн хууль ёсны хүчин төгөлдөр гэрээтэй байх зөвхөн тийм тохиолдолд үүрэг үүсдэг. Хэдийгээр санал болгосон шилжүүлэлт нь нөөцийн хүлээн зөвшөөрөлтөнд хүргэхгүй боловч тухайн төлөвлөсөн ажил гүйлгээг УСНББОУС 14, УСНББОУС 20, *Холбоотой Талуудын Тодруулга* гэх мэт бусад УСНББОУС-уудын дагуу тодруулах шаардлагатай байж болно.

*Бүтцийн өөрчлөлтийн нөөц*

93. **Бүтцийн өөрчлөлтийн нөөц нь уг бүтцийн өөрчлөлтөөс үүсэх ба дараах хоёр шинжийг хоёуланг нь хангах зөвхөн шууд зарлагуудыг агуулсан байна:**
- (a) **Уг бүтцийн өөрчлөлтөөс зайлшгүй хамаарах; ба**
  - (b) **Тухайн байгууллагын тасралтгүй үйл ажиллагаатай холбоогүй байх.**
94. Бүтцийн өөрчлөлтийн нөөцөнд дараах гэх мэт зардлууд хамаарахгүй:
- (a) Үлдэж буй ажилчдыг давтан сургах буюу өөр тийш шилжүүлэх;
  - (b) Маркетинг; эсвэл

- (в) Шинэ систем болон хуваарилалтын сүлжээнд хөрөнгө оруулалт хийх.

Эдгээр зарлагууд нь үйл ажиллагааг ирээдүйд эрхлэн явуулахтай холбоотой бөгөөд тухайн тайлангийн өдрөөр бүтцийн өөрчлөлтөнд хамаарах өр төлбөр биш юм. Бүтцийн өөрчлөлтөөс хамааралгүй байдлаар үүссэн зарлагуудад хэрэглэдэгтэй ижил сууриар ийм зарлагуудыг хүлээн зөвшөөрнө.

95. Бүтцийн өөрчлөлтийн өдөр хүртэлх тодорхойлж болох ирээдүйн үйл ажиллагааны цэвэр алдагдал нь 18-р параграфт тодорхойлсон, алдагдалтай гэрээтэй холбоотой байхаас бусад тохиолдолд тэдгээрийг нөөцөд оруулан тусгахгүй.
96. Хэдийгээр бүтцийн өөрчлөлтийн нэг хэсэг байдлаар хөрөнгийг борлуулахаар төлөвлөсөн байлаа ч гэсэн 61-р параграфтаар шаардсанчлан, хөрөнгийн хүлээгдэж буй данснаас хасалтаас үүсэх олзыг бүтцийн өөрчлөлтийн нөөцийн хэмжилтэнд харгалзан үзэхгүй.

## Тодруулга

97. **Байгууллага нь нөөцийн анги тус бүрийн хувьд дараах зүйлсийг тодруулна:**

- (а) Тухайн тайлант үеийн эхэн ба эцэс дэх дансны үнэ;
- (б) Тухайн тайлант үед байгуулсан нэмэлт нөөц, үүн дотроо одоогийн нөөцийн нэмэгдүүлэлт хамаарна;
- (в) Тухайн тайлант үеийн туршид ашигласан нөөцийн дүн (өөрөөр хэлбэл, зардал гарч, нөөцөөс хаасан);
- (г) Тухайн тайлант үеийн туршид буцаасан ашиглагдаагүй дүн; ба
- (д) Цаг хугацаа урсан өнгөрсний үр дүнд уг дискаунтчилсан дүнд тухайн тайлант үеийн туршид гарсан нэмэгдэлт ба дискаунтын хувь хэмжээний аливаа өөрчлөлтийн үр нөлөө.

**Зэрэгцүүлэгдэх мэдээллийг шаардахгүй.**

98. **Байгууллага нь нөөцийн анги тус бүрийн хувьд дараах зүйлсийг тодруулна:**

- (а) Үүргийн шинж төрөл ба эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн аливаа үр дүнгийн зарлагын хүлээгдэж буй хугацааны талаархи товч тайлбар тодорхойлолт;
- (б) Эдгээр зарлагын дүн буюу хугацааны талаархи тодорхойгүй байдлын шинж тэмдэг. Зохих мэдээллээр хангах шаардлагатай тохиолдолд байгууллага нь 58-р параграфт дурдсанчлан, ирээдүйн үйл явдлуудын талаар хийсэн гол таамаглалуудыг тодруулна; ба

- (в) **Аливаа хүлээгдэж буй нөхөн төлбөрийн дүн, уг хүлээгдэж буй нөхөн төлбөрийн хувьд хүлээн зөвшөөрсөн аливаа хөрөнгийн дүнг илэрхийлэх.**
99. **Байгууллага нь нийлүүлсэн бараа, үйлчилгээнийхээ үнэ цэнэтэй ойролцоогоор тэнцүү төлбөрийг тэдгээр үр өгөөж хүртэгчдээс хариу болгон шууд хүлээн авдаггүй нийгмийн халамжийн хувьд өөрийн санхүүгийн тайландаа нөөцийг хүлээн зөвшөөрөх сонголт хийсэн тохиолдолд тухайн байгууллага нь тэдгээр нөөцийн хувьд 97 ба 98-р параграфтаар шаардсан тодруулгыг хийнэ.**
100. **Төлбөрийг барагдуулахад аливаа зарлага гаргах магадлал маш бага байхаас бусад тохиолдолд байгууллага нь тухайн тайлангийн өдрөөрх болзошгүй өр төлбөрийн анги тус бүрийн хувьд уг болзошгүй өр төлбөрийн шинж төрлийн талаархи товч тайлбар тодорхойлолт, түүнчлэн практик боломжтой тохиолдолд дараах зүйлсийг тодруулна:**
- (а) **44-62-р параграфын дагуу хэмжсэн, түүний санхүүгийн үр нөлөөний тооцоолол;**
- (б) **Аливаа зарлагын дүн буюу хугацаатай холбоотой тодорхойгүй байдлын шинж тэмдэг; ба**
- (в) **Аливаа нөхөн төлбөрийн боломжит байдал.**
101. Нөөцүүд эсвэл болзошгүй өр төлбөрүүдийг нэг анги болгон нэгтгэн нийлүүлж болох эсэхийг тодорхойлохдоо, тухайн зүйлс нь 98(а) ба (б), 100(а) ба (б) параграфын шаардлагуудыг хангахын тулд тэдгээрийн талаархи нэг мэдэгдлийн хувьд хангалттай ижил төсөөтэй шинж чанартай эсэхийг харгалзан үзэх шаардлагатай. Иймээс нэг төрлийн үүрэгтэй холбоотой дүнгүүдийг нөөцийн нэг анги гэж үзэх нь тохиромжтой байж болох боловч байгаль орчны нөхөн сэргээлтийн зардалтай холбоотой дүнгүүд ба шүүхийн зарга маргаантай холбоотой дүнгүүдийг нэг анги гэж үзэх нь тохиромжгүй юм.
102. Нөөц ба болзошгүй өр төлбөр нь нэг цогц нөхцөл байдлаас үүсдэг тохиолдолд уг нөөц болон болзошгүй өр төлбөрийн хоорондох холбоог харуулахуйц тийм арга замаар байгууллага нь 97, 98, 100-р параграфтаар шаардсан тодруулгыг хийнэ.
103. Зарим нөхцөл байдалд байгууллага нь нөөцийг хэмжихийн тулд гаднын үнэлгээг ашиглаж болох юм. Ийм тохиолдолд тэрхүү үнэлгээтэй холбоотой мэдээллийг зохих ёсоор тодруулж болно.
104. Нийлүүлсэн бараа, үйлчилгээнийхээ үнэ цэнэтэй ойролцоогоор тэнцүү төлбөрийг тэдгээр үр өгөөж хүртэгчдээс хариу болгон шууд хүлээн авдаггүй байгууллагын үзүүлсэн нийгмийн халамжаас үүссэн болзошгүй өр төлбөрийн хувьд 100-р параграфт заасан тодруулгын шаардлагуудыг мөрдөхгүй (нийгмийн халамжийг энэ Стандартад хамруулахгүй талаархи хэлэлцүүлгийг 1(а) ба 7-11-р параграфтаас үзнэ үү).

105. **Эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи орох нилээд магадлалтай тохиолдолд байгууллага нь тухайн тайлангийн өдрөөрх болзошгүй хөрөнгийн шинж төрлийн талаархи товч тайлбар тодорхойлолтыг, түүнчлэн 44-62-р параграфт заасан нөөцийн хувьд тогтоосон зарчмуудыг ашиглан хэмжсэн, тэдгээрийн санхүүгийн үр нөлөөний тооцооллыг практик боломжтой хэмжээгээр тодруулна.**
106. Тухайн байгууллагад үр өгөөж нь орно гэсэн ул үндэслэлтэй хүлээлттэй байх зөвхөн тийм тохиолдолд 105-р параграфт заасан тодруулгыг шаардлагуудыг тэдгээр болзошгүй хөрөнгүүдэд мөрдөх зориулалттай байдаг. Өөрөөр хэлбэл, бүх болзошгүй хөрөнгийн талаархи ийм мэдээллийг тодруулах шаардлага тавигдаагүй (болзошгүй хөрөнгийн хэлэлцүүлгийг 39-43-р параграфтаас үзнэ үү). Болзошгүй хөрөнгийн тодруулга нь орлого бий болох магадлалын талаар буруу ойлголт төрүүлэхүйц шинж тэмдэг илэрхийлэхээс зайлсхийх нь чухал ач холбогдолтой юм. Жишээлбэл, улсын секторын байгууллага нь олборлосон тонн тутмын тогтоосон үнэд үндэслэсэн эрхийн шимтгэлийн хариуд өөрийн нэг ордоос олборлолт хийх зөвшөөрлийг хувийн хэвшлийн компанид олгосон бөгөөд тус компани нь олборлолтыг эхэлсэн тохиолдолд уг гэрээнээс болзошгүй хөрөнгө үүснэ. Ийм хэлцлийн шинж төрлийг тодруулахаас гадна, олборлох ашигт малтмалын тоо хэмээ болон хүлээгдэж буй мөнгөн орлогын гүйлгээний хугацааны талаар ул үндэслэлтэй тооцоолол хийж чадах тохиолдолд болзошгүй хөрөнгийг тооцоолж илэрхийлнэ. Хэрэв батлагдсан нөөц байхгүй буюу зонхилох бусад зарим нөхцөл байдал нь ямар нэг ашигт малтмал олборлох магадлал багатай гэдгийг харуулж байвал үр өгөөжийн магадлалт гүйлгээ байхгүй учраас тус улсын секторын байгууллага нь 105-р параграфтаар шаардсан мэдээллийг тодруулахгүй.
107. 105-р параграфт заасан тодруулгын шаардлагууд нь арилжааны болон арилжааны бус ажил гүйлгээний аль алинаас үүссэн болзошгүй хөрөнгөнд хамаарна. Татварын орлоготой холбоотойгоор болзошгүй хөрөнгө оршин байх эсэх нь татвар ногдох үйл явдал гэж юу болох талаархи тайлбарт үндэслэнэ. Татварын орлогын хувьд хийх татвар ногдох үйл явдлын тодорхойлолт, түүнчлэн татварын орлоготой холбоотой болзошгүй хөрөнгийн тодруулгад түүний үзүүлэх боломжит ач холбогдлыг арилжааны бус орлогын талаархи тусдаа төслийн нэг хэсэг байдлаар авч үзнэ.
108. **100 ба 105-р параграфтаар шаардсан аливаа мэдээллийг тодруулах практик боломжгүйн улмаас тодруулга хийгээгүй тохиолдолд энэ тухай тайлбарлан мэдэгдэнэ.**
109. **Туйлын ховор тохиолдолд, 97-107-р параграфтаар шаардсан бүх буюу зарим мэдээллийг тодруулах нь тухайн нөөц, болзошгүй өр төлбөр, болзошгүй хөрөнгийн асуудлаар бусад талуудтай маргаантай байгаа уг байгууллагын байр сууринд ноцтой сөрөг нөлөө үзүүлж болох юм. Ийм тохиолдолд байгууллага нь мэдээллийг тодруулах шаардлагагүй боловч уг мэдээллийг тодруулаагүй тухай болон**



яагаад тодруулаагүй талаархи шалтгааны хамтаар тэрхүү маргааны ерөнхий шинж чанарыг тодруулна.

## Шилжилтийн нөхцөл

110. [Хассан]

## Хүчин төгөлдөр болох хугацаа

111. Байгууллага нь энэхүү Стандартыг 2004 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2004 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 111А. 2011 оны 10 дугаар сард гаргасан *УСНББОУС 2011-ийн Сайжруулалтууд*-аар 5-р параграфыг хасаж, 1 ба 4-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2013 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2013 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 111Б. 2015 оны 01 дүгээр сард гаргасан *УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-ийн үр дүнд 110, 112-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед *УСНББОУС 33-ыг* мөрдсөн бол эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.
- 111В. 2015 оны 01 дүгээр сард гаргасан *УСНББОУС 37, Хамтын Хэлэлцээр*-ийн үр дүнд 37-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь *УСНББОУС 37-г* мөрдсөн үеэс уг нэмэлт өөрчлөлтийг дагаж мөрдөнө.
- 111Г. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд*-аар 6-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.

- 111Д. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 2, 3-р параграфуудыг хассан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 111Е. 2016 оны 7 дугаар сард гаргасан *УСНББОУС 39, Ажилтны Тэтгэмж*-ийн үр дүнд 14-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн *УСНББОУС 39*-ийг мөрдөнө.
- 111Ж. 2017 оны 01 дүгээр сард гаргасан *УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл*-ийн үр дүнд 4А параграфыг шинээр нэмсэн. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн *УСНББОУС 40*-ийг мөрдөнө.
112. *УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт *УСНББОУС*-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд *УСНББОУС*-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ *Стандартыг* мөрдөнө.

**Хүснэгт**

**Нөөц, Болзошгүй Өр Төлбөр, Болзошгүй Хөрөнгө, Нөхөн Төлбөр**

*Эдгээр Хүснэгтүүд нь УСНББОУС 19-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

**Нөөц ба болзошгүй өр төлбөр**

<p><b>Өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн (а) одоогийн үүргийн, эсвэл (б) бүхэлдээ тухайн байгууллагын хяналтанд байдаггүй ирээдүйн нэг буюу хэд хэдэн тодорхой бус үйл явдлын гарч тохиолдолд эсвэл үл тохиолдолтоор бөгөөд түүний оршин байдал нь зөвхөн батлагдах боломжит үүргийн барагдуулалтын хувьд ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцийг зарцуулж болох юм.</b></p>		
<p><b>Нөөцийн зарцуулалтыг шаардах магадлалтай одоогийн үүрэгтэй.</b></p>	<p><b>Боломжит үүрэгтэй, эсвэл нөөцийг зарцуулахыг шаардаж болох боловч ингэж шаардахгүй байх нилээд магадлалтай одоогийн үүрэгтэй.</b></p>	<p><b>Боломжит үүрэгтэй, эсвэл нөөцийг зарцуулах магадлал багатай одоогийн үүрэгтэй.</b></p>
<p>Нөөцийг хүлээн зөвшөөрнө (22-р параграф).</p>	<p>Нөөцийг хүлээн зөвшөөрөхгүй (35-р параграф).</p>	<p>Нөөцийг хүлээн зөвшөөрөхгүй (35-р параграф).</p>
<p>Нөөцийн хувьд тодруулга хийх шаардлагатай (97 ба 98-р параграф).</p>	<p>Болзошгүй өр төлбөрийн хувьд тодруулга хийх шаардлагатай (100-р параграф).</p>	<p>Тодруулга хийх шаардлагагүй (100-р параграф).</p>

Найдвартай хэмжиж чадахгүйн улмаас хүлээн зөвшөөрөөгүй өр төлбөртэй байх туйлын ховор тохиолдолд болзошгүй өр төлбөр бас үүсдэг. Ийм болзошгүй өр төлбөрийн хувьд тодруулга хийх шаардлагатай.

**Болзошгүй хөрөнгө**

<p><b>Өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн бөгөөд түүний оршин байдал нь бүхэлдээ тухайн байгууллагын хяналтанд байдаггүй ирээдүйн нэг буюу хэд хэдэн тодорхой бус үйл явдлын гарч тохиолдолд эсвэл үл тохиолдолтоор зөвхөн батлагдах боломжит хөрөнгө байдаг.</b></p>		
<p><b>Эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн орлогын гүйлгээ нь үнэхээр тодорхой байх.</b></p>	<p><b>Эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн орлогын гүйлгээ нь нилээд магадлалтай боловч үнэхээр тодорхой биш байх.</b></p>	<p><b>Эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн орлогын гүйлгээ нь нилээд магадлалтай биш байх.</b></p>
<p>Уг хөрөнгө нь болзошгүй хөрөнгө байна (41-р параграф).</p>	<p>Хөрөнгийг хүлээн зөвшөөрөхгүй (39-р параграф).</p>	<p>Хөрөнгийг хүлээн зөвшөөрөхгүй (39-р параграф).</p>
	<p>Тодруулга хийх шаардлагатай (105-р параграф).</p>	<p>Тодруулга хийх шаардлагагүй (105-р параграф).</p>

**Нөхөн төлбөр**


<b>Нөөцийг барагдуулахад шаардлагатай зарим буюу бүх зарлагыг өөр нэг тал нөхөн олгохоор хүлээгдэж байх.</b>		
<b>Байгууллага нь уг бусад талаас нөхөн олгогдох зарлагын хэсгийн хувьд үүрэг хүлээдэггүй.</b>	<b>Нөхөн төлөгдөхөөр хүлээгдэж буй дүнгийн хувьд үүрэг нь тухайн байгууллагад үлдэх бөгөөд хэрэв байгууллага нь уг нөөцийг барагдуулвал нөхөн төлбөрийг хүлээн авна гэдэг нь үнэхээр тодорхой байх.</b>	<b>Нөхөн төлөгдөхөөр хүлээгдэж буй дүнгийн хувьд үүрэг нь тухайн байгууллагад үлдэх бөгөөд хэрэв байгууллага нь уг нөөцийг барагдуулвал нөхөн төлбөрийг хүлээн авна гэдэг нь үнэхээр тодорхой биш байх.</b>
Байгууллага нь уг нөхөн олгогдох дүнгийн хувьд өр төлбөргүй байна (67-р параграф).	Нөхөн төлбөрийг санхүүгийн байдлын тайланд тусдаа хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд санхүүгийн үр дүнгийн тайланд тусгасан зардлаас суутган хасаж, цэвэр дүнгээр харуулж болно. Хүлээгдэж буй нөхөн төлбөрийн хувьд хүлээн зөвшөөрсөн дүн нь тухайн өр төлбөрөөс илүүгүй байна (63 ба 64-р параграф).	Хүлээгдэж буй нөхөн төлбөрийг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхгүй (63-р параграф).
Тодруулга хийх шаардлагатай.	Нөхөн төлбөрийг түүний хувьд хүлээн зөвшөөрсөн дүнгийн хамтаар тодруулна (98(в) параграф).	Хүлээгдэж буй нөхөн төлбөрийг тодруулна (98(в) параграф).

## **Үлгэрчилсэн шийдвэрийн мод**

*Энэхүү шийдвэрийн мод нь УСНББОУС 19-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

*Тэмдэглэл: Зарим тохиолдолд одоогийн үүрэгтэй эсэх нь тодорхойгүй байдаг. Ийм тохиолдолд бэлэн, боломжтой байгаа бүх нотолгоог харгалзан үзсэнээр тухайн тайлангийн өдрөөр одоогийн үүрэг оршин байх нь үл оршин байхаас илүү их магадлалтай бол өнгөрсөн үйл явдал нь одоогийн үүрэг үүсэхэд хүргэнэ гэж төсөөлдөг (энэ Стандартын 23-р параграф).*

НӨӨЦ, БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА БОЛЗОШГҮЙ ХӨРӨНГӨ



## Дүгнэлтийн Үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 19-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

**УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд-ын Хэсэг II: “Санал гаргагчдын дэвшүүлсэн асуудлууд”-ын үр дүнд УСНББОУС 19-д хийсэн хянан засварлалт**

ДҮ1. Санал гаргагчид нь борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба данснаас хасах бүлгийг УСНББОУС тууштай бус илэрхийлсэн гэж үзсэн. СТОУС 5, *Борлуулах Зорилгоор Эзэмшиж Буй Эргэлтийн Бус Хөрөнгө ба Зогсоосон Үйл Ажиллагаа* нь дараах учир шалтгааны улмаас зөвхөн зарим нөхцөл байдалд улсын секторт тохиромжтой байж болох юм гэж УСНББОУС3 дүгнэсэн:

- (а) Шаардлагатай түвшний зөвшөөрлийн улмаас улсын секторт хөрөнгийн борлуулалтыг нэг жилийн дотор хийж чадахгүй байж болох юм. Энэ нь СТОУС 5-ын дагуу тусгах мэдээллийн хамааралтай ба тууштай байдалд эргэлзээ үүсгэдэг. Тухайлбал; борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийг СТОУС 5-ын дагуу элэгдүүлэхгүй гэдгийг УСНББОУС3 онцлон тэмдэглэсэн. Хөрөнгийг урт хугацаанд элэгдүүлэхгүй байх нь тохиромжгүй гэж УСНББОУС3 үзэж байна.
- (б) Улсын секторт олон хөрөнгийг үнэгүй эсвэл нэрлэсэн төлбөртэйгээр шилжүүлэх буюу түгээн хуваарилах замаар данснаас хасдаг. СТОУС 5 нь бодит үнэ цэнээр хийх борлуулалтыг авч үздэг тул түүний хэмжилт ба тодруулгын шаардлагууд нь ийм шилжүүлэлтийн хувьд холбогдох мэдээллээр хангадаггүй. Гэвч борлуулалтыг бодит үнэ цэнээр хийх санаа зорилготой байх тохиолдолд СТОУС 5-ын хэмжилт ба тодруулгын шаардлагууд нь тохиромжтой байж болно гэдгийг УСНББОУС3 хүлээн зөвшөөрдөг.
- (в) Улсын сектор дахь зогсоосон олон үйл ажиллагаа нь үнэгүй эсвэл нэрлэсэн төлбөртэйгээр өмнө үзүүлсэн үйлчилгээ байдаг. СТОУС 5 нь данснаас хасах эсвэл борлуулах зорилгоор эзэмшиж буй гэж дахин ангилахаас өмнө мөнгө бий болгогч нэгжүүд буюу мөнгө бий болгогч нэгжүүдийн бүлэг байсан, тийм зогсоосон үйл ажиллагааг авч үздэг тул түүний тодруулгын шаардлагууд нь улсын секторын зогсоосон үйл ажиллагааны хувьд холбогдох мэдээллээр хангадаггүй байж болох юм. Гэвч зогсоосон үйл ажиллагаа нь өмнө нь мөнгө бий болгогч нэгжүүд буюу мөнгө бий болгогч нэгжүүдийн нэг болон хэд хэдэн бүлгүүд байсан бол СТОУС 5-ын тодруулгын шаардлагууд тохиромжтой байж болно гэдгийг УСНББОУС3 хүлээн зөвшөөрдөг.

СТОУС 5 нь зөвхөн цөөн хязгаарлагдмал нөхцөл байдалд улсын секторт тохиромжтой гэж УСНББОУС3 дүгнэсэн учраас борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагааг авч үзэх олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн стандартуудын



талаархи УСНББОУС дахь хэллэг лавлагааг хасахыг УСНББОУСЗ зөвшөөрсөн. Ийм хэллэг лавлагааг хасалгүй үлдээх нь СТОУС 5-ын шаардлагууд тохиромжгүй байж болох нөхцөл байдалд байгууллагууд түүний шаардлагуудыг даган мөрдөхөд хүргэнэ гэж УСНББОУСЗ санаа зовж байсан. УСНББОУС-уудад тусгайлан авч үзээгүй ажил гүйлгээний хувьд нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох заавар удирдамжаар УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого*, *Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* хангана гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Тохиромжтой гэж тухайн байгууллага үзсэн тохиолдолд СТОУС 5-тай нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тэдгээр байгууллагууд баримтлахыг ийм заавар удирдамжаар зөвшөөрсөн байдаг.

**2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУСЗ-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 19-д хийсэн хянан засварлалт**

ДҮ2. УСНББОУСЗ нь 2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (а) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р* параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

## **Хэрэгжүүлэх заавар удирдамж**

*Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 19-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### **Хүлээн зөвшөөрөлт**

- ХЗУ1. Жишээнд дурдсан бүх байгууллагуудын тайлангийн өдөр нь 12 дугаар сарын 31 байна. Хүлээгдэж буй аливаа зарлагын гүйлгээний хувьд бүх тохиолдолд найдвартай тооцоолол хийж чадна гэж үзнэ. Зарим жишээнд дурдсан нөхцөл байдал нь тухайн хөрөнгийн үнэ цэнийн бууралтанд хүргэж болох юм. Энэ асуудлыг эдгээр жишээнүүдэд авч үзээгүй болно.
- ХЗУ2. Жишээнүүдэд оруулсан харилцан лавлагаа нь энэ Стандартын тухайлан хамаарах параграфуудыг илэрхийлнэ. Энэхүү заавар удирдамжийг энэ Стандартын бүрэн текстийн хамт уншвал зохино.
- ХЗУ3. “Хамгийн сайн тооцоолол” гэсэн хэллэг нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн үр нөлөө материаллаг байх үед өнөөгийн үнэ цэнийн дүнд хамаарах болно.

### **Баталгаа**

- ХЗУ4. Засгийн газрын А хэлтэс нь тухайн засгийн газрын хүрээнд ашиглах ба олон нийтэд худалдан борлуулах зорилгоор эрэл хайгуулын болон аврах тоног төхөөрөмжийг үйлдвэрлэдэг. Борлуулалт хийх үедээ тус хэлтэс нь зарим бүтээгдэхүүнтэй холбоотойгоор худалдан авагчдад баталгаа гаргаж өгдөг. Борлуулалтын нөхцлийн дагуу тус Хэлтэс нь борлуулалт хийсэн өдрөөс хойш гурван жилийн дотор илэрсэн үйлдвэрлэлийн гологдлыг засах буюу барааг сольж өгөх хариуцлага хүлээдэг. Өмнөх туршлагаас харахад, ийм баталгааны дагуу зарим нэхэмжлэл гарч ирэх нилээд магадлалтай (өөрөөр хэлбэл, нэхэмжлэл гаргахгүй гэдгээс гаргах нь илүү магадлалтай) байдаг.

### **Шинжилгээ**

Үүрэг хүлээлгэх өнгөрсөн үйл явдлын үр дүн болох одоогийн үүрэг – Үүрэг хүлээлгэх үйл явдал нь бүтээгдэхүүний баталгаатай борлуулалт бөгөөд энэ нь хууль ёсны үүргийг үүсгэдэг.

Үүргийг барагдуулахад эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцийг зарцуулна – Бүхэлдээ баталгааны хувьд нилээд магадлалтай (32-р параграфыг үзнэ үү).

### **Дүгнэлт**

Тухайн тайлангийн өдөр буюу түүнээс өмнө борлуулсан бүтээгдэхүүний баталгааны дагуу барааг засварлах буюу сольж орлуулах зардлын хамгийн сайн тооцооллын хувьд нөөцийг хүлээн зөвшөөрнө (22 ба 32-р параграфыг үзнэ үү).

## **Бохирдуулсан газар – Хүчин төгөлдөр болж мөрдөгдөх нь үнэхээр тодорхой хууль тогтоомж**

ХЗУ5. Орон нутгийн засаг захиргаа нь боомтын ойролцоо газарт байрлах агуулахыг өмчилдөг. Тус орон нутгийн захиргаа нь өөрийн боомтын үйл ажиллагааг ирээдүйд өргөжүүлэхэд шаардлагатай байж болох учраас тухайн газрын өмчлөлийг хадгалан үлдсэн. Хэсэг тариаланч нар хөдөө аж ахуйн зориулалттай химийн бодисыг хадгалахын тулд уг үл хөдлөх хөрөнгийг өнгөрсөн арван жилийн хугацаанд түрээслэж байсан. Үндэсний Засгийн газар нь байгаль орчны бохирдуулалт, үүн дотроо бохирдуулсан газрыг цэвэрлэх зардлын хувьд өр төлбөр хүлээн зөвшөөрөхийг үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч нараас шаардсан байгаль орчны хууль тогтоомж батлан гаргах өөрийн санаа зорилгыг зарлан мэдэгдсэн. Үүний үр дүнд орон нутгийн засаг захиргаа нь химийн хортой бодисны талаархи бодлого гаргаж, тэрхүү бодлогыг өөрийн үйл ажиллагаа болон үл хөдлөх хөрөнгөндөө мөрдөж эхэлсэн. Энэ үе шатанд, хөдөө аж ахуйн зориулалттай химийн бодис нь түүний агуулахын ойр орчмын газрыг бохирдуулсан гэдэг нь тодорхой болжээ. Тус орон нутгийн захиргаа нь цэвэрлэгээний зардлыг тариаланчид болон өөрийн даатгалын компаниар төлүүлэх ямар ч боломжгүй байсан. Өмнө нь бохирдуулсан газрыг цэвэрлэхийг шаардах уг хуулийн төсөл нь тухайн жилийн эцсээс хойш богино хугацааны дотор батлагдан хүчин төгөлдөр болно гэдэг нь 2001 оны 12 дугаар сарын 31-нээр үнэхээр тодорхой болсон.

### **Шинжилгээ**

Үүрэг хүлээлгэх өнгөрсөн үйл явдлын үр дүн болох одоогийн үүрэг – Бохирдуулсан газрыг цэвэрлэхийг шаардах хууль тогтоомж батлагдах нь үнэхээр тодорхой болсон учраас уг газрын бохирдуулалт нь үүрэг хүлээлгэх үйл явдал болох юм.

Үүргийг барагдуулахад эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцийг зарцуулна – Нилээд магадлалтай.

### **Дүгнэлт**

Цэвэрлэх зардлын хамгийн сайн тооцооллын хувьд нөөцийг хүлээн зөвшөөрнө (22 ба 30-р параграфыг үзнэ үү).

## **Бохирдуулалт ба гэрээний бус үүрэг**

ХЗУ6. Засгийн газар нь олон нийтэд хэвлэн тараасан байгаль орчны бодлоготой бөгөөд түүнд зааснаар, өөрийн бохирдуулсан бүх газрыг цэвэрлэх үүрэг хүлээдэг. Засгийн газар нь энэхүү хэвлэн нийтэлсэн бодлогоо сайн хэрэгжүүлдэг. Тухайн улс оронд байгаль орчны хууль тогтоомж байхгүй. Тэнгисийн цэргийн сургуулилалтын явцад усан онгоц гэмтэж, маш их хэмжээний шатахуун асгарсан. Засгийн газар нь нэн даруй цэвэрлэх зардал, түүнчлэн далайн амьтад ба шувуудыг хянан үнэлэх, туслах байнгын зардлыг хариуцан төлөхийг зөвшөөрсөн.

### **Шинжилгээ**

Үүрэг хүлээлгэх өнгөрсөн үйл явдлын үр дүн болох одоогийн үүрэг – Засгийн газрын бодлого ба өмнөх үйл ажиллагаа нь тухайн бохирдуулалтыг засгийн газар арилгаж цэвэрлэнэ гэсэн бодит хүлээлтийг бий болгох учраас гэрээний бус үүрэг үүсгэх уг байгаль орчны бохирдуулалт нь үүрэг хүлээлгэх үйл явдал болно.

Үүргийг барагдуулахад эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцийг зарцуулна – Нилээд магадлалтай.

### **Дүгнэлт**

Цэвэрлэх зардлын хамгийн сайн тооцооллын хувьд нөөцийг хүлээн зөвшөөрнө (22 ба 30-р параграфыг үзнэ үү).

### **Хайрганы карьер**

ХЗУ7. Засгийн газар нь хувийн хэвшлийн компаниас арилжааны сууриар түрээслэсэн газар дээр хайрганы карьер ажиллуулдаг. Хайргыг аюто замын барилгын ажил болон засвар үйлчилгээнд ашигладаг. Газрын эзэдтэй байгуулсан гэрээний дагуу засгийн газар нь бүх барилга, байгууламжийг буулгаж нураах, газрыг хэвийн байдалд оруулах, бүх хөрсийг буцаан тавих үүрэг хүлээсэн. Нөхөн сэргээлтийн нийт зардлын 60 хувь нь тус карьерийн барилга, байгууламжийг буулгаж нураахтай холбоотой, харин 40 хувь нь хайргыг ухаж олборлох явцад хамаарах юм. Тухайн тайлангийн өдрөөр карьерийн барилга, байгууламжийг барьж байгуулсан ба газрыг ухаж эхэлсэн боловч хайргыг ухаж олборлоогүй байна.

### **Шинжилгээ**

Үүрэг хүлээлгэх өнгөрсөн үйл явдлын үр дүн болох одоогийн үүрэг – Барилга байгууламжийг барьж, карьерийн газрыг ухах нь уг гэрээний дагуу тэдгээр барилга, байгууламжаа буулгаж нураах, газар талбайг хэвийн байдалд оруулах хууль ёсны үүрэг үүсгэх учраас энэ нь үүрэг хүлээлгэх үйл явдал болно. Харин хайргын олборлолтоос хамааран хохирлыг арилгах үүрэг тухайн тайлангийн өдрөөр үүсээгүй байна.

Үүргийг барагдуулахад эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцийг зарцуулна – Нилээд магадлалтай.

### **Дүгнэлт**

Барилга, байгууламжийг буулгаж нураах ба газар талбайг хэвийн байдалд оруулахтай холбоотой нийт зардлын 60 хувийн хамгийн сайн тооцооллын хувьд нөөцийг хүлээн зөвшөөрнө (22-р параграфыг үзнэ үү). Эдгээр өртөг зардлыг тус карьерийн өртгийн нэг хэсэг байдлаар тусган оруулна. Хайргыг ухаж олборлох явцад үүсэх 40 хувийн зардлыг тухайн хайргыг олборлох үед аажмаар өр төлбөр байдлаар хүлээн зөвшөөрнө.

### **Мөнгийг буцаан олгох бодлого**

ХЗУ8. Засгийн газрын худалдааны агентлаг нь худалдан авалтын төвлөрсөн агентлаг байдлаар үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд илүүдэл хангамжийн зүйлсийг худалдан авах боломжийг олон нийтэд олгодог. Хэдийгээр хууль ёсны үүрэггүй боловч тус агентлаг нь сэтгэл ханамжгүй худалдан авагчдад тэдгээрийн худалдан авалтын мөнгийг буцаан олгох бодлого баримталдаг. Мөнгийг буцаан олгох түүний бодлогыг олон нийт мэддэг.

#### **Шинжилгээ**

Үүрэг хүлээлгэх өнгөрсөн үйл явдлын үр дүн болох одоогийн үүрэг – Агентлагийн үйл ажиллагаа нь ийм худалдан авалтын хувьд тус агентлаг мөнгийг буцаан олгоно гэсэн бодит хүлээлтийг түүний зарим худалдан авагчдад бий болгох учраас гэрээний бус үүрэг үүсгэх уг хангамжийн зүйлсийн борлуулалт нь үүрэг хүлээлгэх үйл явдал болно.

Үүргийг барагдуулахад эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцийг зарцуулна – Мөнгөө авахаар буцаасан бараатай хувь хэмжээтэй тэнцүү магадлалтай байна (32-р параграфыг үзнэ үү).

#### **Дүгнэлт**

Мөнгөн буцаалтын зардлын хамгийн сайн тоцооллын хувьд нөөцийг хүлээн зөвшөөрнө (18 (гэрээний бус үүргийн тодорхойлолт), 22, 25, 32-р параграфуудыг үзнэ үү).

### **Хэлтсийг татан буулгах–Тайлангийн өдрөөс өмнө хэрэгжээгүй**

ХЗУ9. 2004 оны 12 дугаар сарын 12-нд Засгийн газар нь өөрийн агентлагийн нэг хэлтсийг татан буулгахаар шийдвэрлэсэн. Хамаарах этгээдүүдийн хэн нэгэнд уг шийдвэрийг тухайн тайлангийн өдрөөс (2004 оны 12 дугаар сарын 31-нээс) өмнө хүргэн мэдэгдээгүй бөгөөд энэхүү шийдвэрийг хэрэгжүүлэх өөр ямар нэг арга хэмжээ аваагүй.

#### **Шинжилгээ**

Үүрэг хүлээлгэх өнгөрсөн үйл явдлын үр дүн болох одоогийн үүрэг – Үүрэг хүлээлгэх үйл явдал байхгүй учраас үүрэг үүсэхгүй.

#### **Дүгнэлт**

Нөөцийг хүлээн зөвшөөрөхгүй (22 ба 83-р параграфыг үзнэ үү).

### **Хэлтсийг татан буулгах–Тайлангийн өдрөөс өмнө хэрэгжүүлсэн**

ХЗУ10. 2004 оны 12 дугаар сарын 12-нд Засгийн газар нь өөрийн агентлагийн нэг хэлтсийг татан буулгахаар шийдвэрлэсэн. Засгийн газар нь 2004 оны 12 дугаар сарын 20-ны өдөр уг хэлтсийг татан буулгах дэлгэрэнгүй

## НӨӨЦ, БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА БОЛЗОШГҮЙ ХӨРӨНГӨ

төлөвлөгөөг зөвшөөрөн баталсан ба тус хэлтсийн ажилтнуудад орон тооны цомхтгол хийх мэдэгдлийг өгсөн.

### **Шинжилгээ**

Үүрэг хүлээлгэх өнгөрсөн үйл явдлын үр дүн болох одоогийн үүрэг – Үүрэг хүлээлгэх үйл явдал нь уг шийдвэрийг ажилтнуудад танилцуулсан мэдэгдэл бөгөөд энэ нь тус хэлтсийг татан буулгана гэсэн бодит хүлээлтийг бий болгосон учраас тэрхүү өдрөөс эхлэн гэрээний бус үүрэг үүсгэнэ.

Үүргийг барагдуулахад эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцийг зарцуулна – Нилээд магадлалтай.

### **Дүгнэлт**

Хэлтсийг татан буулгах зардлын хамгийн сайн тооцооллын хувьд нөөцийг 2004 оны 12 дугаар сарын 31-нээр хүлээн зөвшөөрнө (22 ба 83-р параграфыг үзнэ үү).

## **Агаар цэвэршүүлэх шүүлтүүр суурилуулах хуулийн шаардлага**

ХЗУ11. Шинэ хууль тогтоомжийн дагуу орон нутгийн засаг захиргааны байгууллага нь 2005 оны 6 дугаар сарын 30 гэхэд өөрийн нийтийн эзэмшлийн барилгуудад агаар цэвэршүүлэх шинэ шүүлтүүр суурилуулах ёстой. Тус байгууллага нь ийм агаар цэвэршүүлэх шүүлтүүрийг суурилуулаагүй.

### **Шинжилгээ**

(а) 2004 оны 12 дугаар сарын 31-ний тайлангийн өдрөөр

Үүрэг хүлээлгэх өнгөрсөн үйл явдлын үр дүн болох одоогийн үүрэг – Агаар цэвэршүүлэх шүүлтүүр суурилуулах зардал эсвэл тухайн хууль тогтоомжийн дагуу торгууль төлөх тийм үүрэг хүлээлгэх үйл явдал байхгүй учраас үүрэг үүсэхгүй.

### **Дүгнэлт**

Агаар цэвэршүүлэх шүүлтүүр суурилуулах зардлын хувьд нөөцийг хүлээн зөвшөөрөхгүй (22 ба 25-27-р параграфыг үзнэ үү).

### **Шинжилгээ**

(б) 2005 оны 12 дугаар сарын 31-ний тайлангийн өдрөөр

Үүрэг хүлээлгэх өнгөрсөн үйл явдлын үр дүн болох одоогийн үүрэг – Үүрэг хүлээлгэх үйл явдал (шүүлтүүр суурилуулах) гарч тохиолдоогүй учраас уг агаар цэвэршүүлэх шүүлтүүр суурилуулах зардлын хувьд одоогоор үүрэг үүсээгүй байна. Гэвч үүрэг хүлээлгэх үйл явдал гарч тохиолдсон (нийтийн

эзэмшлийн барилгад хууль тогтоомжийг даган мөрдөөгүй) учраас уг хууль тогтоомжийн дагуу торгууль буюу алданги төлөх үүрэг үүсэж болох юм.

Үүргийг барагдуулахад эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцийг зарцуулна – Хууль тогтоомжийг үл даган мөрдсөний улмаас торгууль, алданги төлөх магадлалын үнэлгээ нь уг хууль тогтоомжийн нарийвчилсан зохицуулалт ба хуулийг хэр чанд сахин мөрдүүлдэг эсэхээс хамаарна.

### **Дүгнэлт**

Агаар цэвэршүүлэх шүүлтүүр суурилуулах зардлын хувьд нөөцийг хүлээн зөвшөөрөхгүй. Гэвч торгууль, алданги ногдуулахгүй байхаас ногдуулах нь илүү магадлалтай байх тэрхүү аливаа торгууль, алдангийн хамгийн сайн тооцооллын хувьд нөөцийг хүлээн зөвшөөрнө (22 ба 25-27-р параграфыг үзнэ үү).

### **Орлогын татварын системийн өөрчлөлтийн үр дүнд ажилтнуудыг давтан сургах**

ХЗУ12. Засгийн газар нь орлогын албан татварын системд олон тооны өөрчлөлт оруулсан. Эдгээр өөрчлөлтийн улмаас татварын алба (тайлагнагч байгууллага) нь санхүүгийн үйлчилгээний зохицуулалтын байнгын даган мөрдөлтийг хангахын тулд өөрийн захиргаа удирдлагын болон хяналт шалгалтын ажилтнуудын ихэнх хэсгийг давтан сурган дадлагажуулах шаардлагатай болсон. Тухайн тайлангийн өдрөөр ажилтнуудыг давтан сургалтанд хамруулаагүй байсан.

### **Шинжилгээ**

Үүрэг хүлээлгэх өнгөрсөн үйл явдлын үр дүн болох одоогийн үүрэг – Үүрэг хүлээлгэх үйл явдал (давтан сургалт) гарч тохиолдоогүй учраас үүрэг үүсээгүй байна.

### **Дүгнэлт**

Нөөцийг хүлээн зөвшөөрөхгүй (22 ба 25-27-р параграфыг үзнэ үү).

### **Алдагдалтай гэрээ**

ХЗУ13. Эмнэлэг (тайлагнагч байгууллага) нь үйл ажиллагааны түрээсийн дагуу түрээслэн ашигладаг барилгад түүний угаалгын газар нь үйл ажиллагаагаа явуулдаг. 2004 оны 12 дугаар сард тус угаалгын газар нь шинэ барилга руу нүүсэн. Хуучин барилгын түрээсийн хугацаа нь дараагийн дөрвөн жилийн хугацаанд үргэлжлэх бөгөөд түүнийг цуцлах боломжгүй. Эмнэлэг нь уг барилгыг өөр зориулалтаар ашиглах боломжгүй бөгөөд бусдад дамжуулан түрээслэж болохгүй.

### **Шинжилгээ**

Үүрэг хүлээлгэх өнгөрсөн үйл явдлын үр дүн болох одоогийн үүрэг – Хуулийн ёсны үүрэг үүсгэх тус түрээсийн гэрээг байгуулсан нь үүрэг хүлээлгэх үйл явдал болно.

Үүргийг барагдуулахад эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцийг зарцуулна – Түрээс нь алдагдалтай гэрээ болсон тохиолдолд эдийн засгийн үр өгөөж бүхий нөөцийг зарцуулах нь нилээд магадлалтай юм (Түрээс нь алдагдалтай гэрээ болох хүртэл эмнэлэг нь уг түрээсийг УСНББОУС 13, “Түрээс”-ийн дагуу тайлагнана).

### **Дүгнэлт**

Зайлсхийх боломжгүй түрээсийн төлбөрүүдийн хамгийн сайн тооцооллын хувьд нөөцийг хүлээн зөвшөөрнө (13(б), 22, 76-р параграфуудыг үзнэ үү).

### **Ганц баталгаа**

ХЗУ14. Орон нутгийн засаг захиргаа нь нийтийн үйлчилгээг төлбөртэйгээр үзүүлэх хувийн хэвшлийн оператор компанийн тодорхой зээлд 2004 оны туршид баталгаа гаргасан бөгөөд тэр үед уг операторын санхүүгийн нөхцөл байдал нь сайн байсан. 2005 онд уг операторын санхүүгийн байдал муудаж, 2005 оны 6 дугаар сарын 30-нд уг оператор компани нь дампуурлаа зарласан.

Зээлийн гаргагч нь даатгалын гэрээг зохицуулах олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартуудын дагуу ийм гэрээг даатгалын гэрээ гэж үзэх сонголт хийснээс бусдаар тухайн гэрээ нь УСНББОУС 29-д заасан, санхүүгийн баталгааны гэрээний тодорхойлолтыг хангаж байна. УСНББОУС 29-ийн цар хүрээнд хамаарах санхүүгийн баталгааны гэрээний хувьд УСНББОУС 29-ийн шаардлагуудыг даган мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишээ нь дараах байдалтай байна.

### **Шинжилгээ**

(а) 2004 оны 12 дугаар сарын 31-нээр

Үүрэг хүлээлгэх өнгөрсөн үйл явдлын үр дүн болох одоогийн үүрэг – Хуулийн ёсны үүрэг үүсгэх уг баталгаа гаргалт нь үүрэг хүлээлгэх үйл явдал болно.

Үүргийг барагдуулахад эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцийг зарцуулна – 2004 оны 12 дугаар сарын 31-нээр үр өгөөжийг зарцуулах магадлалгүй байна.

### **Дүгнэлт**

Уг баталгааг бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрнө.



### **Шинжилгээ**

(б) 2005 оны 12 дугаар сарын 31-нээр

Үүрэг хүлээлгэх өнгөрсөн үйл явдлын үр дүн болох одоогийн үүрэг – Хуулийн ёсны үүрэг үүсгэх уг баталгаа гаргалт нь үүрэг хүлээлгэх үйл явдал болно.

Үүргийг барагдуулахад эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцийг зарцуулна – 2005 оны 12 дугаар сарын 31-нээр уг үүргийг барагдуулахын тулд эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцийг зарцуулах нилээд магадлалтай байна.

### **Дүгнэлт**

Уг баталгааг дараагийн тайлант үед доорх хоёр дүнгийн аль өндрөөр хэмжинэ: (а) үүргийн хамгийн сайн тооцоолол (22, 31, 109-р параграфуудыг үзнэ үү), ба (б) анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс тохиромжтой бол УСНББОУС 9, *Арилжааны Ажил Гүйлгээний Орлого*-ын дагуу тооцсон, хуримтлагдсан хорогдуулгыг хассан дүн.

### **Шүүхийн зарга маргаан**

ХЗУ15. 2004 онд болсон нэгэн хүлээн авалтын дараа арван хүн нас барсан бөгөөд энэ нь улсын музейн (тайлагнагч байгууллагын) рестораны борлуулсан хоолны хордлогын үр дүн байж болзошгүй байв. Тухайн байгууллагаас хохирлыг нэхэмжлэх хуулийн ажиллагаа эхэлсэн боловч уг байгууллага тэрхүү хариуцлагыг хүлээн зөвшөөрөөгүй ба маргаан үүссэн. 2004 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланг нийтэд гаргахыг зөвшөөрөх өдөр хүртэл тухайн байгууллагын хуульч нь түүнийг хариуцлага хүлээхгүй байх нилээд магадлалтай гэж зөвлөсөн. Харин байгууллага нь 2005 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланг бэлтгэж байх үед түүний хуульч нь зарга маргааны явцын байдлаас харахад тухайн байгууллага хариуцлага хүлээх нилээд магадлалтай байна гэж зөвлөсөн.

### **Шинжилгээ**

(а) 2004 оны 12 дугаар сарын 31-нээр

Үүрэг хүлээлгэх өнгөрсөн үйл явдлын үр дүн болох одоогийн үүрэг – Санхүүгийн тайланг нийт гаргахыг зөвшөөрөх үед бэлэн боломжтой байсан нотолгоонд үндэслэн үзэхэд өнгөрсөн үйл явдлын үр дүн болох үүрэг үүсээгүй байна.

### **Дүгнэлт**

Музей нь нөөцийг хүлээн зөвшөөрөхгүй (23 ба 24-р параграфыг үзнэ үү). Аливаа зарлагын магадлал маш бага гэж үзэхээс бусад тохиолдолд уг асуудлыг болзошгүй өр төлбөр гэж тодруулна (100 ба 109-р параграф).

### **Шинжилгээ**

(б) 2005 оны 12 дугаар сарын 31-нээр

Үүрэг хүлээлгэх өнгөрсөн үйл явдлын үр дүн болох одоогийн үүрэг – Бэлэн боломжтой байгаа нотолгоонд үндэслэн үзэхэд одоогийн үүрэгтэй байна.

Үүргийг барагдуулахад эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцийг зарцуулна – Нилээд магадлалтай.

### **Дүгнэлт**

Уг үүргийг барагдуулах дүнгийн хамгийн сайн тооцооллын хувьд нөөцийг хүлээн зөвшөөрнө (22-24 ба 109-р параграфыг үзнэ үү).

### **Засвар үйлчилгээ**

ХЗУ16. Зарим хөрөнгийн хувьд тогтмол засвар үйлчилгээнээс гадна хэдэн жил тутамд их засвар хийх буюу сэргээн засварлах, гол эд ангиудыг солиход мэдэгдэхүйц зардал гаргах шаардлагатай байдаг. Хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгүүд нь янз бүрийн ашиглалтын хугацаатай бөгөөд үр өгөөжийг өөр өөр хэв маягаар бүрдүүлдэг тохиолдолд тухайн хөрөнгийн зарлагыг тэдгээр бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваарилах талаархи заавар удирдамжийг УСНББОУС 17, “*Үндсэн хөрөнгө*”-д тусгасан байдаг.

### **Сэргээн засварлах зардал – Хууль тогтоомжийн шаардлага байхгүй**

ХЗУ17. Засгийн газрын хэлтэс нь улсын секторын олон тооны хөлслөгч нарт барилгыг түрээслэн ашиглуулдаг бөгөөд тэрхүү барилгыг халаадаг зуухны доторлогоог техникийн шалтгааны улмаас таван жил тутамд солих шаардлагатай байдаг. Тайлангийн өдрийн байдлаар уг доторлогоог гурван жилийн хугацаанд ашигласан байсан.

### **Шинжилгээ**

Үүрэг хүлээлгэх өнгөрсөн үйл явдлын үр дүн болох одоогийн үүрэг – Одоогийн үүрэггүй.

### **Дүгнэлт**

Нөөцийг хүлээн зөвшөөрөхгүй (22 ба 25-27-р параграфыг үзнэ үү).

Хэдийгээр зарлага гаргах санаа төлөвлөгөө нь тухайн зуухыг үргэлжлүүлэн ажиллуулах буюу доторлогоог солих эсэх шийдвэрээс хамаарах боловч уг байгууллагын ирээдүйн үйл ажиллагаанаас үл хамааран тэрхүү доторлогоог сольж орлуулах үүрэггүй байна. Нөөцийг хүлээн зөвшөөрөхийн оронд уг зуухны доторлогоог таван жилийн хугацаанд элэгдүүлснээр тэрхүү элэгдлийн зардал нь түүний ашиглалт зарцуулалтыг харгалзан тусгана. Дараа гарах дахин доторлогооны

## НӨӨЦ, БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА БОЛЗОШГҮЙ ХӨРӨНГӨ

зардлыг капиталжуулах ба шинэ доторлогоо нэг бүрийн ашиглалт зарцуулалтыг дараагийн таван жилийн турш дахь элэгдлийн зардлаар харуулна.

### **Сэргээн засварлах зардал – Хууль тогтоомжийн шаардлага**

ХЗУ18. Засгийн газрын Зураг Зүйн Үйлчилгээний Алба нь агаарын зураг зүйд ашигладаг өөрийн нисэх онгоцуудад гурван жил тутамд их засвар хийхийг хуулиар шаардсан байдаг.

#### **Шинжилгээ**

Үүрэг хүлээлгэх өнгөрсөн үйл явдлын үр дүн болох одоогийн үүрэг – Одоогийн үүрэггүй.

#### **Дүгнэлт**

Нөөцийг хүлээн зөвшөөрөхгүй (22 ба 25-27-р параграфыг үзнэ үү).

ХЗУ17-р параграфын жишээнд дурдсан, зуухны доторлогоог солих зардлыг нөөц гэж хүлээн зөвшөөрдөггүйтэй адилаар уг нисэх онгоцны их засварын зардлыг нөөц гэж хүлээн зөвшөөрөхгүй. Хэдийгээр их засвар хийх хуулийн шаардлага нь тэрхүү их засварын зардлын хувьд өр төлбөр үүсгэхгүй боловч уг байгууллагын ирээдүйн үйл ажиллагаанаас үл хамааран онгоцонд их засвар хийх үүрэггүй тул тухайн байгууллага нь өөрийн ирээдүйн үйлдлээр, жишээлбэл, онгоцыг худалдан борлуулснаар ирээдүйн зарлагаас зайлсхийж чадах юм.

### **Тодруулга**

*98-р параграфтаар шаардсан тодруулгын хоёр жишээг доор харуулав.*

#### **Баталгаа**

ХЗУ19. Үйлдвэрлэлийн ослоос хамгаалах үүрэг бүхий Засгийн газрын хэлтэс нь аюулгүй байдлын бүтээгдэхүүний худалдан авагч нарт борлуулалт хийх үедээ баталгаа өгдөг. Баталгааны нөхцлийн дагуу тус хэлтэс нь борлуулалтын өдрөөс хойш хоёр жилийн хугацаанд зохих ёсоор ажиллаж чадаагүй зүйлсийг засах буюу сольж өгөх үүрэг хүлээдэг. Тухайн тайлангийн өдрөөр 60,000 мөнгөн нэгжийн нөөцийг хүлээн зөвшөөрсөн. Дискаунтчлалын үр нөлөө нь материаллаг биш тул уг нөөцийн дүнг дискаунтчилдаггүй. Дараах мэдээллийг тодруулна:

*Өнгөрсөн гурван санхүүгийн жилийн туршид борлуулсан бүтээгдэхүүний хүлээгдэж буй баталгааны нэхэмжлэлийн хувьд 60,000 мөнгөн нэгжийн нөөцийг хүлээн зөвшөөрсөн. Энэхүү зарлагын ихэнх хэсэг нь ирэх санхүүгийн жилд гарах ба тухайн тайлангийн өдрийн дараах хоёр жилийн дотор бүх зарлага гарна гэж хүлээгдэж байна.*

*Ашиглалтаас хасах зардал*

ХЗУ20. Эмнэлгийн зориулалтаар ашиглах радио изотоп боловсруулахын тулд цөмийн реакторыг ашигладаг төрийн өмчит судалгааны төв нь 300 сая мөнгөн нэгжийн ашиглалтаас хасах зардлын хувьд 2005 онд нөөцийг хүлээн зөвшөөрсөн. Ашиглалтаас хасах үйл ажиллагааг 60-70 жилийн хугацаанд гүйцэтгэнэ гэсэн таамаглалыг ашигласнаар уг нөөцийг тооцоолсон. Харин ашиглалтаас хасах үйл ажиллагааг 100-110 жил хүртэлх хугацаанд гүйцэтгэхгүй байх магадлалтай бөгөөд ийм урт хугацаатай байх тохиолдолд уг зардлын өнөөгийн үнэ цэнэ мэдэгдэхүйц буурах юм. Дараах мэдээллийг тодруулна:

*Ашиглалтаас хасах зардалд зориулан 300 сая мөнгөн нэгжийн нөөцийг хүлээн зөвшөөрсөн. Уг зардал нь 2065-2075 оны хооронд гарахаар хүлээгдэж байна; гэхдээ ашиглалтаас хасах үйл ажиллагаа нь 2105-2115 он хүртэл үргэлжлэхгүй гэдэг нь магадлалтай юм. Тухайн ашиглалтаас хасах үйл ажиллагаа нь 2105-2115 он хүртэл үргэлжлэхгүй гэсэн хүлээлтэнд зардлыг хэмжсэн бол нөөцийн дүн нь 136 сая мөнгөн нэгж хүртэл буурах байсан. Одоо байгаа технологи, одоогийн үнийг ашиглаж, 2 хувийн дискаунтын бодит хувь хэмжээгээр дискаунтчилснаар уг нөөцийг тооцоолсон.*

**Тодруулгаас чөлөөлөх**

*109-р параграфтаар шаардсан тодруулгын жишээг доор харуулсан бөгөөд шаардсан зарим мэдээлэл нь тухайн байгууллагын байр суурийг хэт нэг талыг баримтлан илэрхийлэхээр хүлээгдэж буй тул тусган харуулаагүй болно.*

ХЗУ21. Генетикийн материалыг ашиглах үедээ засгийн газрын судалгааны агентлаг нь патентын эрх зөрчсөн гэсэн гомдлыг түүний эсрэг гаргаж, 100 сая мөнгөн нэгжийн хохирол нэхэмжилсэн компанитай уг агентлаг нь шүүхийн маргаантай байна. Тус судалгааны агентлаг нь тухайн үүргийн хамгийн сайн тооцооллын хувьд нөөцийг хүлээн зөвшөөрдөг боловч энэ Стандартын 97 ба 98-р параграфтаар шаардсан мэдээллийг тодруулаагүй. Дараах мэдээллийг тодруулна:

*Тус агентлагийг патентын эрх зөрчсөн гэж үзэн гомдол гаргаж, 100 сая мөнгөн нэгжийн хохирол нэхэмжилсэн компанитай холбоотой шүүхийн зарга маргаантай байгаа. УСНББОУС 19, “Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө”-өөр ихэвчлэн шаарддаг мэдээллийг тухайн зарга маргааны үр дүнд ноцтойгоор нөлөөлнө гэсэн үндэслэлээр тодруулаагүй болно. Удирдах Зөвлөл нь уг хохирлын нэхэмжлэлийг агентлаг амжилттай хамгаалж чадна гэсэн санал дүгнэлттэй байна.*

## Үлгэрчилсэн жишээ

Энэхүү жишээ нь УСНББОУС 19-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

### Нөөцийн өнөөгийн үнэ цэнэ

Нөөцийн өнөөгийн үнэ цэнийн анхны хүлээн зөвшөөрөлт болон уг нөөцийн өнөөгийн үнэ цэнийн нэмэгдэлтийн дараагийн тайлант үеийн хүлээн зөвшөөрөлтийн үед хийгдэх журналын бичилтүүдийг дараах жишээнд үлгэрчлэн харуулав. Нөөцийн нэмэгдэлтийг хүүний зардал гэж хүлээн зөвшөөрнө (70-р парагарф).

ҮЖ1. 5 дахь жилийн эцэс дэх нөөцийн хүлээгдэж буй үнэ цэнэ нь 2,000 мөнгөн нэгж байна. Энэхүү хүлээгдэж буй үнэ цэнийг эрсдлээр тохируулаагүй. Уг мөнгөн гүйлгээтэй холбоотой эрсдлийг харгалзсан тохиромжтой дискаунтын хувь хэмжээг 12 хувь гэж тооцоолсон.

ҮЖ2. Жил бүр нөөц болон нөөцийн үнэ цэнийн өөрчлөлтийг бүртгэх журналын бичилтийг доор харуулав:

Тухайн тайлант үеийн эцэст

Дебит	Зардал	1,134.85	
Кредит	Нөөц		1,134.85

1 дэх жилийн эцэст

Дебит	Хүүний зардал	136.18	
Кредит	Нөөц		136.18

2 дахь жилийн эцэст

Дебит	Хүүний зардал	152.52	
Кредит	Нөөц		152.52

3 дахь жилийн эцэст

Дебит	Хүүний зардал	170.83	
Кредит	Нөөц		170.83

НӨӨЦ, БОЛЗОШГУЙ ӨР ТӨЛБӨР БА БОЛЗОШГУЙ ХӨРӨНГӨ

4 дэх жилийн эцэст

Дебит	Хүүний зардал	191.33	
Кредит	Нөөц		191.33

5 дахь жилийн эцэст

Дебит	Хүүний зардал	214.29	
Кредит	Нөөц		214.29

**Тооцоолол:**

**Нэмэгдэлт**

Тайлант хугацаа:	$\text{Өнөөгийн үнэ цэнэ} = 2,000 / (1.12)^5 = 1,134.85$	-
1 дэх жилийн эцэст:	$\text{Өнөөгийн үнэ цэнэ} = 2,000 / (1.12)^4 = 1,271.04$	136.18
2 дахь жилийн эцэст:	$\text{Өнөөгийн үнэ цэнэ} = 2,000 / (1.12)^3 = 1,423.56$	152.52
3 дахь жилийн эцэст:	$\text{Өнөөгийн үнэ цэнэ} = 2,000 / (1.12)^2 = 1,594.39$	170.83
4 дэх жилийн эцэст:	$\text{Өнөөгийн үнэ цэнэ} = 2,000 / (1.12)^1 = 1,785.71$	191.33
5 дахь жилийн эцэст:	$\text{Өнөөгийн үнэ цэнэ} = 2,000 / (1.12)^0 = 2,000.00$	214.29

## НББОУС 37-ТОЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 19-ийг НББОУС 37 (1998)-гоос үндсэндээ бэлтгэсэн. УСНББОУС 19 ба НББОУС 37-гийн хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- Нийлүүлсэн бараа, үйлчилгээнийхээ үнэ цэнэтэй ойролцоогоор тэнцүү төлбөрийг тэдгээр үр өгөөж хүртэгчдээс хариу болгон шууд хүлээн авдаггүй байгууллагын үзүүлсэн нийгмийн халамжаас үүсэх нөөц ба болзошгүй өр төлбөрт УСНББОУС 19-ийг мөрдөхгүй гэдгийг түүний цар хүрээ хэсэгт заасан. Гэвч байгууллага нь нийгмийн халамийн хувьд нөөцийг хүлээн зөвшөөрөх сонголт хийсэн бол УСНББОУС 19 нь энэ талаар зарим тодруулга хийхийг шаардана.
- Алдагдалтай гэрээ байх тохиолдолд нөөц гэж хүлээн зөвшөөрсөн нөхөн төлбөрийг хассан цэвэр одоогийн үүрэг байна гэдгийг тодорхой болгохын тулд НББОУС 37 дахь тод хар үсгээр бичсэн хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулж, НББОУС 37-д зааснаас гадна нэмэлт тайлбарыг УСНББОУС 19-д оруулсан.
- Ажилтны тэтгэмжээс үүсэх нөөц, болзошгүй өр төлбөр, болзошгүй хөрөнгө нь энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй боловч энэ Стандартад дурдсан бүтцийн өөрчлөлтийн үр дүн болох ажлаас халагдалтын тэтгэмжээс үүсэх нөөц, болзошгүй өр төлбөр, болзошгүй хөрөнгөнд УСНББОУС 19-ийг мөрдөнө гэдгийг түүний цар хүрээний параграфт тодорхой заасан.
- УСНББОУС 19 нь зарим тохиолдолд НББОУС 37-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь УСНББОУС 19 дэх “орлого” /revenue/, “санхүүгийн үр дүнгийн тайлан” гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. НББОУС 37 дахь адилтгах нэр томъёо нь “орлого” /income/ ба “орлогын тайлан” юм.
- УСНББОУС 19 нь НББОУС 37-д ашигласан техникийн нэр томъёоны тодорхойлолт, түүнчлэн “бүрэн биелэгдээгүй гэрээ”-нд хамаарах нэмэлт тодорхойлолтыг агуулсан байдаг.
- Улсын секторыг илүү сайн тусгахын тулд Хэрэгжүүлэх Заавар Удирдамжинд нэмэлт өөрчлөлт оруулсан.
- УСНББОУС 19 нь дискаунтын хүчин зүйлийн үр нөлөөний улмаас нөөцийн үнэ цэнэд цаг хугацааны явцад гарах өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөх журналын бичилтүүдийг харуулсан Үлгэрчилсэн Жишээг агуулсан байдаг.

## УСНББОУС 20–ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) 24, *Холбоотой Талуудын Тодруулга* (1994 онд хянан засварласан)-аас үндсэндээ бэлтгэсэн болно. НББОУС 24-өөс авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон EC4M 6XH, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)

Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.



## УСНББОУС 20-ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА

### УСНББОУС-ын түүх

Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

УСНББОУС 20, Холбоотой Талуудын Тодруулга-ыг 2002 оны 10 дугаар сард гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 20-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС 39, Ажилтны Тэтгэмж (2016 оны 7 дугаар сард гаргасан)
- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 37, Хамтын Хэлэлцээр (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 35, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС-ын Сайжруулалтууд (2010 оны 11 дүгээр сард гаргасан)

### УСНББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт

Өөрчлөгдсөн параграф	Хэрхэн өөрчилсөн	Юугаар өөрчилсөн
2	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
3	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
4	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар
15	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар
24	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
27	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
32	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
33	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар

ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА

38	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 39, 2016 оны 7-р сар
42А	Шинэ	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
42Б	Шинэ	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
42В	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
42Г	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
42Д	Шинэ	УСНББОУС 39, 2016 оны 7-р сар
43	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар

**УСНББОУС 20–ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА****АГУУЛГА**

	Параграф
Зорилго	
Цар хүрээ	1-3
Тодорхойлолт	4-17
Хувь хүний гэр бүлийн ойрын гишүүн	5
Эрх бүхий албан тушаалтан	6-9
Холбоотой тал	10-15
Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	16
Саналын бүрэн эрх	17
Холбоотой талын асуудал	18-21
Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	21
Материаллаг байдал	22
Тодруулга	23-41
Хяналтын тодруулга	25-26
Холбоотой талын ажил гүйлгээний тодруулга	27-33
Тодруулга-Эрх бүхий албан тушаалтан	34-41
Хүчин төгөлдөр болох хугацаа	42-43
Дүгнэлтийн үндэслэл	
Хэрэгжүүлэх заавар удирдамж	
НББОУС 24-тэй харьцуулалт	

## ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 20, *Холбоотой Талуудын Тодруулга*-ыг зорилго хэсэг болон 1-43-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 20-ийг түүний зорилгын агуулга, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

Энэ Стандартын зорилго нь хяналт үүссэн тохиолдолд холбоотой талуудын харилцааны оршин байдлын талаархи тодруулга, түүнчлэн зарим нөхцөл байдалд тухайн байгууллага ба түүний холбоотой талуудын хоорондох ажил гүйлгээний талаархи мэдээллийн тодруулга хийхийг шаарддаг. Ийм мэдээлэл нь тайлагналын хариуцлагын зорилгын хувьд түүнчлэн уг тайлагнагч байгууллагын санхүүгийн байдал ба үр дүнгийн талаар илүү сайн ойлголт олж авахад зайлшгүй шаардлагатай байдаг. Холбоотой талуудын талаархи мэдээллийг тодруулах үндсэн асуудал нь (а) тухайн тайлагнагч байгууллагыг хянадаг буюу түүнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг талуудыг тогтоох, (б) тэдгээр талуудтай хийгдсэн ажил гүйлгээний талаар ямар мэдээллийг тодруулах хэрэгтэй эсэхийг тодорхойлох явдал юм.

## Цар хүрээ

1. Нягтлан бодох бүртгэлийн аккрузл суурийн дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь холбоотой талуудын харилцаа болон холбоотой талуудтай хийсэн зарим ажил гүйлгээний талаархи мэдээллийг тодруулахдаа энэ Стандартыг мөрдөнө.
2. [Хассан]
3. [Хассан]

## Тодорхойлолт

4. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

Хувь хүний гэр бүлийн ойрын гишүүд гэдэг нь уг байгууллагатай тэдгээрийн холбогдох ажил хэргийн харилцааны явцад тэрхүү хувь хүнд нөлөө үзүүлэх эсвэл тэр хувь хүний нөлөөнд орохоор хүлээгдэж буй гэр бүлийн гишүүд буюу ойрын төрөл садангийн хүмүүс юм.

Эрх бүхий албан тушаалтан гэдэг нь дараах хүмүүс юм:

- (а) Тухайн байгууллагын бүх захирлууд буюу удирдах зөвлөлийн гишүүд; ба
- (б) Уг тайлагнагч байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, удирдан чиглүүлэх, хянах бүрэн эрх ба үүрэг хариуцлага бүхий бусад хүмүүс. Энэхүү шалгуурыг хангаж байх тохиолдолд эрх бүхий албан тушаалтанд дараах хүмүүс хамаарна:
  - (i) Тайлагнагч байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, удирдан чиглүүлэх, хянах бүрэн эрх ба үүрэг хариуцлага бүхий төрийн байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн байгаа тохиолдолд тэрхүү гишүүн;

- (ii) Тэрхүү гишүүний аливаа гол зөвлөгчид; ба
- (iii) Дээрх (а)-д нэгэнт хамрагдсан байхаас бусад тохиолдолд тухайн тайлагнагч байгууллагын дээд түвшний удирдлагын бүлэг, үүнд: уг байгууллагын гүйцэтгэх захирал буюу орон тооны дарга;

Хяналт гэдэг нь байгууллагын үйл ажиллагааг хянах, санхүүгийн болон үйл ажиллагааны шийдвэрүүдийг хянах буюу мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх бүрэн эрх ба үүрэг хариуцлагатай байхыг хэлнэ.

Холбоотой тал: хэрэв нэг тал нь (а) нөгөө талыг хянах, эсвэл (б) санхүүгийн болон үйл ажиллагааны шийдвэр гаргахад уг нөгөө талд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх чадвар боломжтой эсвэл тэрхүү холбоотой тал болох байгууллага ба нөгөө байгууллага нь нэг ерөнхий хяналтанд байдаг бол тэдгээр талуудыг холбоотой гэж үзнэ. Холбоотой талуудад дараах этгээд хамаарна:

- (а) Нэг болон хэд хэдэн дундын зуучлагчдаар дамжуулан уг тайлагнагч байгууллагыг шууд буюу шууд бусаар хянадаг эсвэл түүний хяналтанд байдаг байгууллагууд;
- (б) Хараат байгууллагууд (УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*-ыг үзнэ үү);
- (в) Тайлагнагч байгууллагад мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх боломжийг олгох хувь оролцоог уг байгуулагад шууд буюу шууд бусаар өмчилдөг хувь хүмүүс болон ийм аливаа хувь хүний гэр бүлийн ойрын гишүүд;
- (г) Эрх бүхий албан тушаалтан ба уг эрх бүхий албан тушаалтны гэр бүлийн ойрын гишүүд; ба
- (д) Өмчлөлийн мэдэгдэхүйц хувь оролцоог нь дээрх (в) эсвэл (г)-д дурдсан аливаа хувь хүн шууд буюу шууд бусаар эзэмшдэг эсвэл ийм хувь хүн нь мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх чадвар боломжтой байдаг байгууллагууд.

Холбоотой талын ажил гүйлгээ гэдэг нь үнийг нэхэмжилсэн эсэхээс үл хамааран холбоотой талуудын хооронд хийгдэх нөөцийн буюу үүргийн шилжүүлэлт юм. Уг тайлагнагч байгууллагаас эсвэл өөрөө нэг хэсэг нь болох засгийн газраас зөвхөн эдийн засгийн хувьд хараат байгаагийн улмаас холбоотой тал болдог бусад аливаа байгууллагатай хийсэн ажил гүйлгээ нь холбоотой талын ажил гүйлгээнд хамаардаггүй.

Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал гэдэг нь удирдах зөвлөлийн гишүүний эсвэл өөр бусад байдлаар уг тайлагнагч байгууллагын ажилтны хувьд өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд үзүүлсэн үйлчилгээнийхээ төлөө тухайн тайлагнагч байгууллагаас тэрхүү эрх бүхий албан тушаалтны шууд буюу шууд бусаар авч буй аливаа төлбөр болон тэтгэмж юм.

**Мэдэгдэхүйц нөлөө** гэдэг нь (энэ Стандартын зорилгын хувьд) байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогын шийдвэрт оролцох бүрэн эрхтэй боловч тэдгээр бодлогыг хянадаггүй байхыг хэлнэ. Мэдэгдэхүйц нөлөөг ихэвчлэн удирдах зөвлөл буюу адилтгах удирдах байгууллага дахь төлөөллөөр дамжуулан хэрэгжүүлдэг боловч мөн тухайлбал, дараах байдлаар хэд хэдэн арга замаар хэрэгжүүлж болно. Үүнд: (а) бодлого боловсруулах процессод оролцох, (б) эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрэн дэх байгууллагуудын хоорондох материаллаг ажил гүйлгээнд оролцох, (в) удирдах ажилтнуудыг харилцан солилцох, (г) техникийн мэдээллээс хамааралтай байлгах. Өмчлөлийн хувь оролцоо, дүрэм буюу гэрээгээр мэдэгдэхүйц нөлөөг тогтоож болох юм. Өмчлөлийн хувь оролцооны хувьд УСНББОУС 36-д заасан тодорхойлолтын дагуу мэдэгдэхүйц нөлөөг урьдчилан төсөөлдөг.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь-д* дахин нийтэлсэн болно.

#### **Хувь хүний гэр бүлийн ойрын гишүүн**

5. Хувь хүнийг энэ Стандартын зорилгоор тухайн нэг хувь хүний гэр бүлийн ойрын гишүүн гэж үзэх эсэхийг тодорхойлохдоо шүүн тунгаалт хийх шаардлагатай байдаг. Тухайн хувь хүнээс түүний эхнэр/нөхөр буюу бусад хамаатан садан нь салж хөндийрсэн гэсэн нотолгоо байхгүй тохиолдолд гэр бүлийн дараах шууд гишүүд болон ойрын хамаатан саданг уг хувь хүний гэр бүлийн ойрын гишүүд гэсэн тодорхойлолтыг хангана эсвэл хангахуйц тийм нөлөөтэй гэж урьдчилан төсөөлнө:
- (а) Эхнэр/нөхөр, хамтран амьдрагч, асрамж халамжинд байгаа хүүхэд буюу нэг гэрт хамт амьдарч буй хамаатан садан;
  - (б) Өвөө эмээ, эцэг эх, насанд хүрсэн хүүхэд, ач зээ, ах, эгч;
  - (в) Хүүхдийнх нь эхнэр/нөхөр буюу хамтран амьдрагч, хадам эцэг эх, хадам ах эгч, хадам дүү.

#### **Эрх бүхий албан тушаалтан**

6. Уг тайлагнагч байгууллагын удирдах зөвлөл нь тэрхүү байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, удирдан чиглүүлэх, хянах бүрэн эрхтэй ба үүрэг хариуцлагатай тохиолдолд тэрхүү удирдах зөвлөлийн гишүүд болон тухайн тайлагнагч байгууллагын бүх захирлууд нь эрх бүхий албан тушаалтанд хамаарна. Нийт засгийн газрын түвшинд удирдах зөвлөл нь сонгогдсон буюу томилогдсон төлөөлөгчдөөс (жишээлбэл; ерөнхийлөгч, ерөнхий сайд, сайдууд, иргэдийн төлөөлөгчид, засаг дарга буюу тэдгээрт нэр дэвшигчид) бүрддэг байж болох юм.

7. Тухайн байгууллага өөрөө харъяалагдан захирагддаг засгийн газрын удирдах зөвлөлийн сонгогдсон буюу томилогдсон төлөөлөгч нь тус байгууллагад хяналт тавьдаг бөгөөд түүний хяналтын чиг үүрэгт нь уг байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, удирдан чиглүүлэх, хянах бүрэн эрх ба үүрэг хариуцлага хамаардаг бол тэрхүү хүн нь эрх бүхий албан тушаалтанд хамаарна. Олон улс оронд, тэрхүү эрх бүхий хүний гол зөвлөгч нар нь эрх бүхий албан тушаалтны тодорхойлолтыг хангах тийм хангалттай бүрэн эрх, хуулийн буюу бусад эрхгүй байж болох юм. Харин зарим улс оронд тэрхүү эрх бүхий хүний гол зөвлөгч нар нь тухайн байгууллагыг хянадаг уг эрх бүхий хүнтэй ажил хэргийн тусгай харилцаатайн улмаас тэдгээр зөвлөгчдийг эрх бүхий албан тушаалтан гэж үзэж болох юм. Иймээс тэдгээр зөвлөгчид нь мөн нууц мэдээлэлд хандан нэвтрэх эрхтэй бөгөөд тухайн байгууллагыг хянадаг буюу мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг байж болно. Хувь хүн нь гол зөвлөгч эсэх, мөн уг зөвлөгч нь эрх бүхий албан тушаалтан буюу холбоотой талын тодорхойлолтыг хангах эсэхийг үнэлэхдээ шүүн тунгаалт хийх шаардлагатай байдаг.
8. Удирдах зөвлөл, түүнчлэн гүйцэтгэх захирал болон дээд түвшний удирдлагын бүлэг нь тухайн байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх ба хянах, түүний нөөц болон байгууллагын зорилтуудын ерөнхий биелэлтийг удирдан зохицуулах бүрэн эрх ба үүрэг хариуцлагатай байдаг. Иймээс эрх бүхий албан тушаалтанд тухайн тайлагнагч байгууллагын гүйцэтгэх захирал болон дээд түвшний удирдлагын бүлэг хамаардаг. Зарим улс оронд төрийн албан хаагч нь нийт засгийн газрын түвшний тайлагнагч байгууллагын эрх бүхий албан тушаалтан байх (энэ Стандартад тодорхойлсончлон) шалгуурыг хангах хангалттай бүрэн эрх, үүрэг хариуцлагагүй байдаг. Ийм тохиолдолд эрх бүхий албан тушаалтан нь тухайн засгийн газрын хувьд хамгийн их үүрэг хариуцлага бүхий удирдах зөвлөлийн зөвхөн сонгогдсон гишүүдээс бүрддэг; тэдгээр хүмүүсийг ихэвчлэн Засгийн газрын гишүүн сайд гэж нэрлэдэг.
9. Эдийн засгийн нэгдмэл байгууллагын дээд түвшний удирдлагын бүлэг нь хяналт тавигч байгууллага болон уг эдийн засгийн нэгдмэл байгууллагыг хамтдаа бүрдүүлж буй бусад байгууллагуудын аль алинд хамаараах хүмүүсээс бүрдэж болох юм.

#### **Холбоотой тал**

10. Холбоотой талуудын боломжит харилцаа нэг бүрийг авч үзэх үедээ уг харилцааны зөвхөн хуулийн хэлбэрт биш, харин мөн чанарт анхаарал хандуулдаг.
11. Хоёр байгууллага нь дундын нэг эрх бүхий албан тушаалтантай тохиолдолд энэ хүн нь хоёр байгууллагын ажил хэргийн явцад тэдний аль алины бодлогод нөлөө үзүүлэх чадвар боломжтой эсэхийг харгалзан үзэх ба магадлалыг үнэлэх шаардлагатай байдаг. Гэвч зөвхөн дундын нэг эрх бүхий албан тушаалтантай байх нь заавал холбоотой талын харилцааг үүсгэх албагүй юм.



12. Энэ Стандартын хүрээнд дараах этгээдийг холбоотой талууд гэж үзэхгүй:
- (а) Байгууллагатай өөрсдийн хэвийн ажил хэргээр зөвхөн холбогддог (хэдийгээр тэд уг байгууллагын үйл ажиллагааны чөлөөт байдалд нөлөөлөх буюу түүний шийдвэр гаргалтанд оролцож болох боловч) дараах этгээдүүд:
    - (i) Өөрсдийн ажил хэргийн явцад тэр чиглэлийн санхүүжилтээр хангадаг байгууллага;
    - (ii) Үйлдвэрчний эвлэл;
  - (б) Зөвхөн агентлагийн харилцаатай байдаг байгууллага.
13. Хувь хүн нь удирдах зөвлөлийн гишүүн байх эсвэл уг тайлагнагч байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны шийдвэрт оролцдог тохиолдолд холбоотой талуудын харилцаа үүсэж болох юм. Уг тайлагнагч байгууллага ба холбоотой талын хоорондох үйл ажиллагааны хөндлөнгийн харилцааны явцад мөн холбоотой талуудын харилцаа үүсэж болох юм. Ийм харилцаа нь эдийн засгийн тодорхой хэмжээний хараат байдлыг ямагт агуулсан байдаг.
14. Нэг байгууллага нь нөгөө байгууллагаас хараат, өөрөөр хэлбэл, мэдэгдэхүйц хэмжээний санхүүжилт буюу бараа, үйлчилгээний борлуулалтын хувьд уг нөгөө байгууллагаас хамааралтай байх тийм эдийн засгийн хараат байдал нь дангаараа хяналт буюу мэдэгдэхүйц нөлөөлөлд хүргэх магадлал багатай, иймээс холбоотой талуудын харилцаа үүсгэх магадлалгүй юм. Улсын секторын байгууллага нь мэдэгдэхүйц хэмжээний ажил гүйлгээгээ хийдэг ганцхан худалдан авагч, бэлтгэн нийлүүлэгч, франчайз өмчлөгч, дистрибьютор буюу ерөнхий агент нь зөвхөн энэхүү эдийн засгийн хараат байдлын улмаас холбоотой тал болохгүй юм. Гэвч эдийн засгийн хараат байдал нь бусад хүчин зүйлсийн хамтаар мэдэгдэхүйц нөлөө, улмаар холбоотой талуудын харилцаа үүсгэж болох юм. Ийм харилцаанд эдийн засгийн хараат байдлын үзүүлэх үр нөлөөг үнэлэхдээ шүүн тунгаалт хийх шаардлагатай байдаг. Тайлагнагч байгууллага нь өөр байгууллагаас эдийн засгийн хувьд хараат байх тохиолдолд уг тайлагнагч байгууллага нь ийм хараат байдлын талаар тодруулга хийхийг дэмжинэ.
15. Тайлагнагч байгууллагын эрх бүхий албан тушаалтан, тийм хүмүүсийн гэр бүлийн ойрын гишүүд эсвэл гол хувьцаа эзэмшигчдийн (уг байгууллага нь өмчийн албан ёсны бүтэцгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчидтэй адилтгах эдгээдийн) өмчилдөг байгууллагууд нь холбоотой талын тодорхойлолтонд хамаарна. Мөн нэг тал нь нөгөө талд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх чадвар боломжтой байх тийм нөхцөл байдал нь холбоотой талын тодорхойлолтонд хамаарах юм. Улсын секторын хувьд, хувь хүн буюу байгууллага нь уг тайлагнагч байгууллагад хяналт тавих үүрэг хариуцлагатай боловч тэрхүү тайлагнагч байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны шийдвэрийг хянадаггүй байж болно. Энэхүү Стандартын зорилгоор хамтарсан үйлдвэрийг агуулах тийм байдлаар мэдэгдэхүйц нөлөөг тодорхойлдог.

### **Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал**

16. Удирдах зөвлөлийн гишүүний эсвэл өөр бусад байдлаар уг тайлагнагч байгууллагын ажилтны хувьд өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд үзүүлсэн үйлчилгээнийхээ төлөө тухайн тайлагнагч байгууллагаас тэрхүү хувь хүний авч буй аливаа цалин урамшуулал нь эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулалд хамаардаг. Ажилтан эсвэл удирдах зөвлөлийн гишүүнээс өөр бусад, аливаа бүрэн эрхийн хүрээнд үзүүлсэн үйлчилгээнийхээ төлөө тухайн байгууллагаас шууд буюу шууд бусаар авч буй тэтгэмж нь энэ Стандартад заасан эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын тодорхойлолтыг хангахгүй юм. Гэвч ийм бусад зарим тэтгэмжийн талаар тодруулга хийхийг 34-р параграфтаар шаардсан байдаг. Ажлын шугамаар явсан томилолттой холбоотой байрны зардлын нөхөн төлбөр гэх мэт уг тайлагнагч байгууллагын тусын тулд тэдгээр хүмүүсийн гаргасан зардлыг зөвхөн нөхөн олгох байдлаар өгсөн аливаа төлбөр нь эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулалд хамаарахгүй.

### **Саналын бүрэн эрх**

17. Тайлагнагч байгууллагад мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх боломжийг олгох тэрхүү байгууллагын саналын эрхийн хувь оролцоог шууд буюу шууд бусаар өмчилдөг аливаа хувь хүмүүс нь холбоотой талын тодорхойлолтонд хамаарна. Улсын секторын байгууллага нь корпорацийн бүтэцтэй бөгөөд сайд эсвэл засгийн газрын агентлаг нь тухайн байгууллагын хувьцааг эзэмшдэг тохиолдолд уг байгууллагын саналын эрхийн хувь оролцооны эзэмшилт үүсдэг.

### **Холбоотой талын асуудал**

18. Дараах шалтгааны улмаас улсын секторт холбоотой талуудын харилцаа үүсдэг:
- (а) Засаг захиргааны нэгжүүд нь гүйцэтгэх засаглалын, эцэстээ Улсын Их Хурал буюу түүнтэй адилтгах сонгогдсон эсвэл томилогдсон албан тушаалтны ерөнхий чиглэл удирдлагад захирагдаж, тухайн засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэхийн төлөө хамтран ажилладаг байх;
  - (б) Засгийн газрын хэлтэс ба агентлагууд нь үүрэг хариуцлага ба зорилтуудынхаа янз бүрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааг ихэвчлэн тэдний хяналтанд буй тусдаа байгууллагуудаар болон өөрсдөө мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг байгууллагуудаар дамжуулан эрхлэн явуулдаг байх; ба
  - (в) Сайдууд эсвэл засгийн газрын болон дээд түвшний удирдлагын бүлгийн бусад сонгогдсон буюу томилогдсон гишүүд нь хэлтэс, агентлагийн үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг байх.
19. Дараах шалтгааны улмаас зарим холбоотой талуудын харилцаа болон холбоотой талуудын ажил гүйлгээ, тэдгээр ажил гүйлгээний суурь үндэслэл болох харилцааны талаархи тодруулга нь тайлагналын

зорилгод зайлшгүй шаардлагатай бөгөөд уг тайлагнагч байгууллагын санхүүгийн тайланг илүү сайн ойлгох боломжийг хэрэглэгчдэд олгодог:

- (а) Холбоотой талуудын харилцаа нь өөрийн бие даасан зорилтуудад хүрэхийн тулд бусад байгууллагуудтай ажил хэргээ эрхлэн явуулах уг байгууллагын арга зам болон нийтлэг буюу хамтын зорилтууддаа хүрэх үүднээс бусад байгууллагуудтай хамтран ажиллах түүний арга замд нөлөө үзүүлдэг байх;
- (б) Холбоотой талуудын харилцаа нь хэрэв ийм харилцаа байгаагүй бол үл оршин байх тийм эрсдэлд уг байгууллагыг өртүүлдэг эсвэл боломж олгодог байж болох юм; ба
- (в) Холбоотой талууд нь харилцан хамааралгүй этгээдүүд хийхээргүй байсан тийм ажил гүйлгээг хийдэг эсвэл харилцан хамааралгүй талуудын хувьд хэвийн боломжтой байхаас өөр нөхцөл, болзлоор ажил гүйлгээ хийхийг зөвшөөрдөг байж болох юм. Тухайн тайлагнагч байгууллагын болон засгийн газрын зорилтуудын хэрэгжүүлэлттэй нийцсэн хэвийн үйл ажиллагааны горимын нэг хэсэг байдлаар бараа, үйлчилгээг түүний бүрэн өртөг нөхөлтөөс бага дүнгээр засгийн газрын хэлтсүүд болон агентлагуудын хооронд шилжүүлдэг, засгийн газрын хэлтэс, агентлагийн хувьд ийм тохиолдол байнга гардаг. Засгийн газар болон улсын секторын бие даасан байгууллагууд нь нөөцийг үр ашигтай, үр дүнтэй ба зориулалтын дагуу ашиглаж, улсын мөнгийг хамгийн үнэнч шударгаар зарцуулна гэж тэднээс хүлээдэг. Холбоотой талуудын харилцаа оршин байна гэдэг нь нэг тал нь нөгөө талыг хянах буюу мэдэгдэхүйц нөлөө үзүүлж чадна гэсэн үг юм. Энэ нь нөгөө талдаа ашиггүй давуу талыг нэг талд зүй бусаар олгож болох тийм байдлаар ажил гүйлгээг хийх боломж бүрдүүлдэг.

20. Холбоотой талуудын хоорондох зарим төрлийн ажил гүйлгээ, тэдгээрийг хийсэн нөхцөл, болзлын талаархи тодруулга нь тухайн байгууллагын санхүүгийн байдал, үр дүнд тэдгээр ажил гүйлгээний үзүүлэх үр нөлөө, тохиролцсон үйлчилгээг үзүүлэх уг байгууллагын чадвар боломжийг үнэлэх боломжийг хэрэглэгчдэд олгодог. Ийм тодруулга нь холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний хувьд уг байгууллага ил тод байсан эсэхийг мөн ханган магадалдаг.

### **Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал**

21. Эрх бүхий албан тушаалтан нь тухайн байгууллагад хариуцлагатай албан тушаал хашдаг. Тэд уг байгууллагын стратегийн чиглэл ба үйл ажиллагааны менежментийг хариуцаж, томоохон эрх мэдэлтэй байдаг. Тэдний цалин хөлсийг ихэвчлэн компанийн дүрмээр, эсвэл хараат бус зөвлөл буюу уг байгууллагаас хараат бус бусад этгээд тогтоодог. Гэвч тэдний үүрэг хариуцлага нь тэдэнд болон тэдний холбоотой талуудад орох уг байгууллагын үр өгөөжид нөлөөлөх боломжийг тэдгээр хүмүүст олгодог байж болох юм. Энэ Стандарт нь дараах зүйлсийн талаар тодруулга хийхийг шаарддаг. Үүнд: (а) тухайн тайлант үеийн туршид уг

эрх бүхий албан тушаалтан буюу түүний гэр бүлийн ойрын гишүүдэд олгосон цалин урамшуулал, (б) тэдэнд олгосон зээл, (в) удирдах зөвлөлийн гишүүн буюу ажилтнаас өөр бусад этгээдийн хувьд тухайн байгууллагад үзүүлсэн үйлчилгээний төлөө тэдэнд олгосон төлбөр. Энэ Стандартаар шаардсан тодруулга нь эрх бүхий албан тушаалтан болон тэдний гэр бүлийн ойрын гишүүдэд олгосон цалин урамшууллын хувьд хамаарах ил тод байдлын хамгийн наад захын зохих түвшинг ханган магадалдаг.

## Материаллаг байдал

22. УСНББОУС 1 нь материаллаг зүйлсийн талаар тусдаа тодруулга хийхийг шаарддаг. Тухайн зүйлийн шинж төрөл буюу хэмжээг харгалзан үзсэнээр материаллаг байдлыг тодорхойлдог. Холбоотой талуудын ажил гүйлгээний материаллаг байдлыг үнэлэх үед уг тайлагнагч байгууллага ба холбоотой талын хоорондох харилцааны шинж төрөл, тухайн ажил гүйлгээний шинж төрөл нь хэмжээнээс үл хамааран тэрхүү ажил гүйлгээ материаллаг гэдгийг илэрхийлж болох юм.

## Тодруулга

23. Олон улс орны хувьд, холбоотой талууд ба холбоотой талуудын ажил гүйлгээний тодорхой ангиллын талаархи мэдээллийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн болон улсын үйлдвэрийн газрын санхүүгийн тайланд тодруулахыг хууль тогтоомж ба санхүүгийн тайлагналын бусад дүрэм журмаар шаардсан байдаг. Тухайлбал; байгууллагын зүгээс өөрийн захирлууд буюу удирдах зөвлөлийн гишүүдтэй, түүнчлэн дээд түвшний удирдлагын бүлэгтэй хийсэн ажил гүйлгээнд, ялангуяа тэдэнд олгосон цалин урамшуулал ба зээлд ихээхэн анхаарал хандуулдаг. Энэ нь (а) захирлууд, удирдах зөвлөлийн гишүүд болон дээд түвшний удирдлагын бүлэгт итгэмжлэн хүлээлгэсэн хариуцлага, ба (б) тэд нь тухайн байгууллагын нөөцийг ашиглан зарцуулах маш их эрх мэдэлтэй байдагтай холбоотой юм. Зарим улс орны хувьд, улсын секторын байгууллагуудад мөрдөх дүрэм болон зохицуулалтанд үүнтэй адилтгах шаардлагуудыг тусгасан байдаг.
24. Зарим УСНББОУС нь холбоотой талуудын ажил гүйлгээний талаар тодруулга хийхийг бас шаарддаг. Жишээлбэл; УСНББОУС 1 нь хяналт тавигч байгууллагууд, хяналтанд буй байгууллагууд, хараат байгууллага ба бусад холбоотой талуудад өгөх болон тэднээс авах дүнгийн талаар тодруулга хийхийг шаарддаг. УСНББОУС 38, *Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцооны Тодруулга* нь эдийн засгийн нэгдмэл байгууллагын бүтэц бүрэлдэхүүнийг ойлгох боломжийг түүний нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгох тийм мэдээлэл, түүнчлэн уг тайлагнагч байгууллагын хувьд материаллаг байх хамтын хэлэлцээр болон хараат байгууллага тус бүрийн талаархи мэдээллийг тодруулахыг тухайн байгууллагаас шаарддаг.

**Хяналтын тодруулга**

25. **Хяналт оршин буй тохиолдолд тэдгээр холбоотой талуудын хооронд ажил гүйлгээ хийгдсэн эсэхээс үл хамааран холбоотой талуудын харилцааг тодруулна.**
26. Уг тайлагнагч байгууллагад холбоотой талуудын харилцааны үзүүлэх үр нөлөөний талаар санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ойлголт өгөхийн тулд хяналт оршин буй тохиолдолд тэдгээр холбоотой талуудын хооронд ажил гүйлгээ хийгдсэн эсэхээс үл хамааран холбоотой талуудын харилцааг тодруулах нь зохистой байдаг. Ийм тодруулга нь хяналтанд буй аливаа байгууллагуудын нэрс, шууд хяналт тавигч байгууллагын нэр, хэрэв байгаа бол эцсийн хяналт тавигч байгууллагын нэрийг тусгасан байдаг.

**Холбоотой талын ажил гүйлгээний тодруулга**

27. **Хэрэв байгууллага нь тухайн нэг хувь хүн буюу байгууллагатай харилцан хамааралгүй байдлаар ижил нөхцөл байдалд уг ажил хэргийг гүйцэтгэсэн бол түүний мөрдөж хэрэглэнэ гэж ул үндэслэлтэйгээр хүлээж болох нөхцлөөс илүү тааламжтай эсвэл тааламжгүй биш, тийм нөхцөл, болзлын дагуу бэлтгэн нийлүүлэгч ба үйлчлүүлэгч/хүлээн авагчийн хэвийн харилцааны хүрээнд хийгдэх байсан ажил гүйлгээнээс өөр байх, холбоотой талуудын ажил гүйлгээний хувьд уг тайлагнагч байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:**
- (а) Холбоотой талуудын харилцааны шинж төрөл;
  - (б) Хийгдсэн ажил гүйлгээний төрөл; ба
  - (в) Түүний үйл ажиллагаанд тэдгээр ажил гүйлгээний үзүүлэх мэдэгдэхүйц нөлөөлөл, түүнчлэн шийдвэр гаргалтын болон тайлагналын зорилгын хувьд хамааралтай ба үнэн зөв төлөөлөх мэдээллээр тухайн санхүүгийн тайлан хангах боломжийг бүрдүүлэхэд хангалттай эсэхийг тодруулахад зайлшгүй шаардлагатай уг ажил гүйлгээний элементүүд.
28. Холбоотой талуудын ажил гүйлгээ нь уг тайлагнагч байгууллага тодруулга хийхэд хүргэж болох нөхцөл байдлуудын жишээг доор харуулав:
- (а) Үйлчилгээ үзүүлэх буюу хүлээн авах;
  - (б) Барааны (бэлэн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүний) худалдан авалт буюу шилжүүлэлт/борлуулалт;
  - (в) Үл хөдлөх хөрөнгө ба бусад хөрөнгийн худалдан авалт буюу шилжүүлэлт/борлуулалт;
  - (г) Агентын хэлцэл;
  - (д) Түрээсийн гэрээ;

- (е) Судалгаа ба хөгжүүлэлтийн шилжүүлэлт;
- (ж) Лицензийн гэрээ;
- (и) Санхүүжилт (зээл, капиталын хувь оролцоо, мөнгөн буюу мөнгөн бус буцалтгүй тусламж болон санхүүгийн бусад дэмжлэг, үүн дотроо өртөг-хуваах хэлцэл); ба
- (к) Баталгаа ба барьцаа.

29. Улсын секторын байгууллагууд нь өөр хоорондоо өдөр тутам ажил гүйлгээ байнга хийж байдаг. Ийм ажил гүйлгээг өртгөөр нь, өртгөөс бага дүнгээр, эсвэл үнэ төлбөргүй хийж болох юм. Жишээлбэл; захиргааны үйлчилгээ үзүүлдэг засгийн газрын хэлтэс нь бусад хэлтэс байгууллагуудыг оффисын байраар үнэ төлбөргүй хангадаг, эсвэл улсын секторын байгууллага нь улсын секторын бусад байгууллагуудын өмнөөс худалдан авалтын агентын үүрэг гүйцэтгэдэг байж болох юм. Засгийн газрын зарим бүтэц загварын хувьд үзүүлсэн үйлчилгээний бүрэн өртгөөс илүү нөхөн төлбөр авах боломжтой байж болно. Ийм хэлтэс байгууллагууд нь нэг ерөнхий хяналтанд байдаг бөгөөд тэдгээр ажил гүйлгээ нь холбоотой талуудын ажил гүйлгээний тодорхойлолтыг хангадаг. Гэвч дараах тохиолдолд тэдгээр байгууллагуудын хоорондох ажил гүйлгээний талаархи мэдээллийг тодруулах шаардлагагүй байдаг. Үүнд: ажил гүйлгээ нь (а) тэдгээр байгууллагуудын хоорондох үйл ажиллагааны хэвийн харилцаатай нийцдэг, (б) тухайн нөхцөлд ийм ажил гүйлгээний хувьд хэвийн байх тийм нөхцөл, болзлоор хийгдсэн. Ийм холбоотой талуудын ажил гүйлгээг 27-р параграфын тодруулгын шаардлагаудаас чөлөөлөх нь тэдгээр улсын секторын байгууллагууд нэг нийтлэг зорилгод хүрэхийн тулд хамтран ажилладаг гэдгийг харуулах бөгөөд янз бүрийн улс орон дахь улсын секторын байгууллагуудын үзүүлэх үйлчилгээний хувьд өөр өөр механизмыг хэрэглэж болно гэдгийг илэрхийлнэ. Холбоотой талуудын ажил гүйлгээ нь тухайн улс орны хувьд тогтоосон үйл ажиллагааны үзүүлэлтүүдээс өөр байдлаар хийгдсэн зөвхөн тийм тохиолдолд энэ Стандарт нь холбоотой талуудын ажил гүйлгээний талаархи тодруулга хийхийг шаарддаг.

30. Нийтлэг зорилготой санхүүгийн тайлагналын зорилтуудыг хангахын тулд тодруулга хийх шаардлагатай холбоотой талуудын ажил гүйлгээний талаархи мэдээлэлд дараах зүйлс хамаарна:

- (а) Эдгээр ажил гүйлгээнд оролцсон холбоотой талуудтай хийсэн харилцааны шинж төрлийн талаархи тайлбар тодорхойлолт. Жишээлбэл; тухайн харилцаа нь хяналт тавигч байгууллага, хяналтанд буй байгууллага, ерөнхий хяналтанд байгаа байгууллага эсвэл эрх бүхий албан тушаалтны аль нэгэнтэй холбоотой эсэх;
- (б) Тусгайлан заасан мөнгөн дүн эсвэл тухайн ажил гүйлгээний анги ба/буюу үлдэгдлийн хувь жин байдлаар харуулсан, ажил гүйлгээний ерөнхий анги тус бүрийн хүрээн дэх холбоотой талуудын ажил гүйлгээний тайлбар тодорхойлолт болон тэрхүү ангийн тоо хэмжээний үзүүлэлт;

- (в) Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний ерөнхий нөхцөл болон болзлын товч тойм, үүнд: эдгээр нөхцөл, болзлууд нь харилцан хамааралгүй талуудтай хийсэн ижил төсөөтэй ажил гүйлгээнд ихэвчлэн хамаарах нөхцлүүдээс ямар ялгаатай талаархи тодруулга;
  - (г) Төлөгдөөгүй байгаа зүйлсийн дүн буюу харгалзах хувийн жин.
31. Байгууллага ба эрх бүхий албан тушаалтан, уг эрх бүхий албан тушаалтны гэр бүлийн ойрын гишүүдийн хоорондох зарим ажил гүйлгээний талаар нэмэлт тодруулга хийхийг энэхүү Стандартын 34-р параграфтаар шаардсан байдаг.
32. **Шийдвэр гаргалтын болон тайлагналын зорилгын хувьд хамааралтай ба үнэн зөв илэрхийлэх мэдээллээр хангахад тусдаа тодруулга шаардлагатай байхаас бусад тохиолдолд ижил төсөөтэй шинж төрөл бүхий зүйлсийг нэгтгэн нийлүүлснээр тодруулж болох юм.**
33. Нэгтгэсэн санхүүгийн тайлан нь хяналт тавигч байгууллага ба хяналтанд буй байгууллагуудын талаархи мэдээллийг тайлагнагч нэг байгууллага байдлаар толилуулдаг тул эдийн засгийн нэгдмэл байгууллагын гишүүдийн хооронд хийгдсэн холбоотой талуудын ажил гүйлгээг нэгтгэсэн санхүүгийн тайланд тодруулах шаардлагагүй байдаг. Хөрөнгө оруулалтын байгууллага ба түүний ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг хяналтанд буй байгууллагуудын хоорондох ажил гүйлгээнээс бусад, уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрэн дэх байгууллагуудын хооронд хийгдсэн холбоотой талуудын ажил гүйлгээг УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*-гийн дагуу нэгтгэх үедээ устгаж цэвэрлэнэ. Харин өмчийн аргаар тайлагнадаг хараат байгууллагуудтай хийсэн ажил гүйлгээг устгахгүй, иймээс холбоотой талуудын ажил гүйлгээ байдлаар тусад нь тодруулах шаардлагатай.

#### **Тодруулга-Эрх бүхий албан тушаалтан**

34. **Байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:**
- (а) **Эрх бүхий ажилтнуудын нийт цалин урамшуулал ба энэ ангиллын хүрээнд цалин урамшуулал авдаг бөгөөд бүтэн цагаар ажилладагтай адилтгах сууриар тодорхойлсон хүмүүсийн тоо, үүнд: эрх бүхий албан тушаалтны гол ангиуд, түүнчлэн анги тус бүрийн тайлбар тодорхойлолтыг тусдаа харуулах;**
  - (б) **Эрх бүхий албан тушаалтан болон түүний гэр бүлийн ойрын гишүүдэд тухайн тайлант үеийн туршид уг тайлагнагч байгууллагын олгосон бусад бүх цалин урамшуулал ба нөхөн төлбөрийн нийт дүн, үүнд: дараах этгээдэд олгосон нийт дүнг тусад нь харуулна:**
    - (i) **Эрх бүхий албан тушаалтан;**

- (ii) **Эрх бүхий албан тушаалтны гэр бүлийн ойрын гишүүд.**
  - (в) **Эрх бүхий албан тушаалтан биш хүмүүст нийтлэг олгох боломжгүй зээл ба олон нийт түүний олгогдох боломжийн талаар ерөнхийдөө мэддэггүй зээлийн хувьд дараах зүйлсийг эрх бүхий албан тушаалтан бүрээр болон уг эрх бүхий албан тушаалтны гэр бүлийн ойрын гишүүн нэг бүрээр тодруулна:**
    - (i) **Тухайн тайлант үеийн туршид олгосон зээлийн дүн ба түүний хугацаа, нөхцөл;**
    - (ii) **Тухайн тайлант үеийн туршид буцаан төлсөн зээлийн дүн;**
    - (iii) **Бүх зээл ба авлагын эцсийн үлдэгдлийн дүн; ба**
    - (iv) **Тухайн хувь хүн нь уг байгууллагын захирал эсвэл удирдах зөвлөлийн буюу дээд түвшний удирдлагын бүлгийн гишүүн биш байх тохиолдолд ийм зөвөл болон бүлэгтэй тэрхүү хүний холбогдох харилцаа.**
35. Тухайн байгууллагын хувьд тогтоосон үйл ажиллагааны нөхцөлтэй нийцсэн, арилжааны сууриас өөр сууриар хийгдсэн холбоотой талуудын ажил гүйлгээг тодруулахыг энэ Стандартын 27-р параграфтаар шаардсан байдаг. 34-р параграфт тодорхойлсон эрх бүхий албан тушаалтантай хийсэн зарим ажил гүйлгээ нь тухайн байгууллагын хувьд мөрдөх үйл ажиллагааны нөхцлүүдтэй нийцсэн, арилжааны сууриар хийгдсэн эсэхээс үл хамааран тэдгээр ажил гүйлгээний талаархи мэдээллийг тодруулахыг энэ Стандартаар бас шаарддаг.
36. Эрх бүхий албан тушаалтан хүн нь бүтэн цагаар эсвэл хагас цагаар ажилладаг байж болох юм. Цалин урамшуулал авдаг гэж 34(а) параграфын дагуу тодруулах хүмүүсийн тоог бүтэн цагтай адилтгах сууриар тооцоолох ёстой. Байгууллага нь өөрийн үндсэн эрх бүхий албан тушаалтнуудын гол ангиудын талаар тусад нь тодруулга хийнэ. Жишээлбэл; байгууллага нь өөрийн дээд түвшний удирдлагын бүлгээс тусдаа байх тийм удирдах зөвлөлтэй бол энэхүү хоёр зөвлөл, бүлгийн цалин урамшууллын талаархи тодруулгыг тус тусад нь хийнэ. Хэрэв нэг хувь хүн нь удирдах зөвлөл ба дээд түвшний удирдлагын бүлгийн аль алины гишүүн бол тэрхүү хувь хүнийг энэ Стандартын зорилгоор уг хоёр бүлгийн зөвхөн нэгэнд хамруулан оруулна. Эрх бүхий албан тушаалтны тодорхойлолтонд дурдсан эрх бүхий албан тушаалтны ангиллууд нь эрх бүхий албан тушаалтны ангиудыг тодорхойлох удирдамжаар хангадаг.
37. Эрх бүхий албан тушаалтны шагнал урамшуулал нь шууд ба шууд бус янз бүрийн тэтгэмжүүдийг агуулсан байдаг. Эдгээр тэтгэмжийн дүн тодорхой бол тухайн тодруулсан нийт цалин урамшуулалд тэтгэмжийн дүнг оруулан тусгана. Харин эдгээр тэтгэмжийн дүн тодорхой биш бол уг тайлагнагч байгууллага буюу байгууллагууд гарах тэтгэмжийн зардлын талаархи хамгийн сайн тооцоолыг хийж, тэрхүү тодруулсан нийт цалин урамшуулалд тусган оруулна.



38. Ажилтны тэтгэмжийн хэмжилтийн талаархи шаардлагуудыг УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-д заасан байдаг. Найдвартай<sup>1</sup> хэмжих боломжтой мөнгөн бус цалин урамшууллыг тухайн тайлант үед тодруулсан, эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын нийт дүнд мөн тусган оруулдаг тохиолдолд тэрхүү мөнгөн бус цалин урамшууллын хэмжилтийн суурийг уг санхүүгийн тайлангийн тэмдэглэлд бас тодруулна.
39. Дараах тохиолдолд эрх бүхий албан тушаалтан ба түүний гэр бүлийн ойрын гишүүдэд олгосон зээлийн нөхцөл, болзлын талаархи зарим мэдээллийн тодруулга хийхийг энэхүү Стандартаар шаарддаг:

- (а) Зээлийг эрх бүхий албан тушаалтан биш хүмүүст нийтлэг олгох боломжгүй байх; ба
- (б) Зээлийг эрх бүхий албан тушаалтан биш хүмүүст нийтлэг олгох боломжтой боловч олон нийт түүний олгогдох боломжийн талаар ерөнхийдөө мэддэггүй байх.

Тайлагналын зорилгын хувьд ийм мэдээллийн тодруулга шаардлагатай байдаг. Энэ Стандартын шаардлагуудыг хангахын тулд ямар зээлийг тодруулах хэрэгтэй эсэхийг тодорхойлохын тулд шүүн тунгаалт хийх шаардлагатай байж болох юм. Холбогдох баримт материалыг харгалзан үзсэний дараа, тухайн санхүүгийн тайлагналын зорилтуудын биелэлттэй нийцсэн байдлаар ийм шүүн тунгаалтыг хийвэл зохино.

40. Эрх бүхий албан тушаалтны нийт цалин урамшууллын талаар тодруулга хийхийг энэ Стандартын 34(а) параграфтаар шаардсан байдаг. Эрх бүхий албан тушаалтанд уг байгууллагын захирлууд буюу удирдах зөвлөлийн гишүүд болон дээд түвшний удирдлагын бүлгийн гишүүд хамаардаг. Тухайн байгууллагын захирлууд буюу удирдах зөвлөлийн гишүүд нь доор дурдсанаас бусад байдлаар үзүүлсэн үйлчилгээнийхээ төлөө уг байгууллагаас мөн цалин урамшуулал буюу нөхөн төлбөрийг авч болох юм: (а) уг байгууллагын захирал буюу удирдах зөвлөлийн гишүүн байдлаар, эсвэл (б) уг байгууллагын ажилтан байдлаар. Энэхүү бусад цалин урамшуулал буюу нөхөн төлбөрийн нийт дүнгийн талаар тодруулга хийхийг энэ Стандартын 34(б)(i) параграфтаар шаарддаг.
41. Эрх бүхий албан тушаалтны гэр бүлийн ойрын гишүүд нь уг тайлагнагч байгууллагатай өөрсдийн хийсэн ажил гүйлгээний явцад эрх бүхий албан тушаалтанд нөлөө үзүүлэх буюу тэдний нөлөөнд ордог байж болох юм. Эрх бүхий албан тушаалтны гэр бүлийн ойрын гишүүдэд тухайн тайлант үеийн туршид олгосон нийт цалин урамшуулал ба нөхөн төлбөрийн талаар тодруулга хийхийг энэ Стандартын 34(б)(ii) параграфтаар шаарддаг.

---

<sup>1</sup> Найдвартай мэдээлэл нь материаллаг алдаа ба туйлшралаас ангид байх бөгөөд өөрийн илэрхийлэхээр зориулагдсан буюу илэрхийлнэ гэж ул үндэслэлтэйгээр хүлээж болох зүйлсийг үнэн зөв илэрхийлэхдээ хэрэглэгчдээс хамаардаг байж болох юм. Найдвартай байдлын тайлбарын талаархи шилжилтийн арга хандлагыг УСНББОУС 1-ийн ДҮ16-р параграфт авч хэлэлцсэн.

## Хүчин төгөлдөр болох хугацаа

42. Байгууллага нь энэхүү Стандартыг 2004 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2004 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 42А. 2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-ийн үр дүнд 43-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед УСНББОУС 33-ыг мөрдсөн бол уг нэмэлт өөрчлөлтийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.
- 42Б. 2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 37, *Хамтын Хэлэлцээр*, УСНББОУС 38, *Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцооны Тодруулга*-ын үр дүнд 4, 15, 24, 33-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь УСНББОУС 35, УСНББОУС 37, УСНББОУС 38-ыг мөрдсөн үеэс эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг дагаж мөрдөнө.
- 42В. 2016 оны 4 дүгээр сард гаргасан УСНББОУС 2015-ын *Сайжруулалтууд*-аар 27, 32-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 42Г. 2016 оны 4 дүгээр сард гаргасан УСНББОУС-ын *Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 2, 3-р параграфуудыг хассан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 42Д. 2016 оны 7 дугаар сард гаргасан УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийн үр дүнд 38-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн

**тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 39-ийг мөрдөнө.**

43. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

## Дүгнэлтийн Үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 20-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

**2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУС3-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 20-д хийсэн хянан засварлалт**

ДҮ1. УСНББОУС3 нь 2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (а) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р* параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

## **Хэрэгжүүлэх заавар удирдамж**

*Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 20-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### **Тодруулга – “Х” засгийн газар**

“Х” засгийн газрын санхүүгийн тайланд дараах тодруулгыг хийсэн.

*Хяналтанд буй байгууллагууд (25-р параграф)*

Засгийн газар нь доор дурдсан тайлагнагч байгууллагуудыг хянадаг:

Засгийн газрын хэлтсүүд ба агентлагууд: Боловсрол, Нийгмийн Хамгаалал, Цагдаа, Шуудан холбоо, Ажил үйлчилгээ, Батлан хамгаалах, Хууль зүй, Төрийн сан/Санхүү, “Х” хэлтэс, “ХҮЗ” агентлаг (бүх хэлтэс, агентлагуудыг тодорхойлох).

Улсын Үйлдвэрийн Газрууд: Засгийн газрын Эрчим хүчний компани, Засгийн газрын Цахилгаан холбооны компани (улсын секторын худалдаа арилжааны бүх байгууллагуудыг тодорхойлох).

(Жич: УСНББОУС 35 нь хяналтанд буй томоохон байгууллагуудын талаар зарим тодруулга хийхийг шаарддаг.)

*Холбоотой талуудын ажил гүйлгээ (27-р параграф)*

Засгийн газрын нэг гишүүнд хаузыг улсын нийслэлд түрээсийн төлбөргүйгээр олгосон. Энэ сайдад олгосонтой ижил хаузыг жилд ойролцоогоор Z мөнгөн нэгжээр түрээслэдэг. Орон байраар хангалт нь уг сайдад олгох цалин урамшууллын багцын бүрэлдэхүүн хэсэг биш бөгөөд сайдуудыг үнэ төлбөргүй орон байраар ерөнхийдөө хангадаггүй. Гэвч энэ тохиолдолд уг сайдад нийслэл хотод орон байр олгох шаардлагатай байсан.

Засгийн газрын өөр нэг гишүүний хамтран амьдрагчид автомашиныг түрээсийн төлбөргүйгээр ашиглуулдаг. Ингэж ашиглуулж буй автомашинтай ижил машиныг жилд ойролцоогоор K мөнгөн нэгжээр түрээслэдэг. Засгийн газар нь сайдуудын хамтран амьдрагч нарт түрээсийн төлбөргүйгээр автомашиныг ерөнхийдөө ашиглуулдаггүй.

*Эрх бүхий албан тушаалтан (34-р параграф)*

### **Цалин урамшуулал (34(а) параграф)**

Уг эрх бүхий албан тушаалтнууд (УСНББОУС 20, *Холбоотой Талуудын Тодруулга*-д тодорхойлсноор) нь “Х” засгийн газрын танхимыг хамтдаа бүрдүүлэх засгийн газрын гишүүд юм. Засгийн газрын гишүүдийн нийт цалин урамшуулал ба уг “Х” засгийн газраас цалин урамшуулал авдаг, бүтэн цагтай адилтгах сууриар тодорхойлсон хүмүүсийн тоо дараах байдалтай байна:

Нийт цалин урамшуулал Х сая.  
Хүмүүсийн тоо У хүн.

**Дээд түвшний удирдлагын бүлэгт хамаарахгүй хүмүүст нийтлэг олгох боломжгүй (түүний олгогдох боломжийн талаар олон нийт ерөнхийдөө мэддэггүй) зээл (34(в) параграф)**

Тайлант үеийн туршид авсан ба буцаан төлсөн ийм зээлийн дүн болон тухайн тайлант үеийн эцэс дэх төлөгдөөгүй үлдэгдлийг доор харуулав:

<u>Хувь хүн</u>	<u>Олгосон</u>	<u>Буцаан төлсөн</u>	<u>Үлдэгдэл</u>
Ноён ABC	J	K	L
Хатагтай VSL	M	N	P
Ноён D	Q	R	Z
Ноён E	S	T	U

### **Хугацаа ба нөхцөл**

Тээврийн сайд ноён ABC нь зах зээлийн хүүнийн түвшнээс Y хувиар бага буюу жилийн X хүүтэйгээр зээлийг авсан. Зээлийн хугацаа нь Z жил байна.

Эрүүл мэндийн сайдын хамтран амьдрагч хатагтай VSL нь засгийн газраас зээл авсан. Зээл нь N жилийн хугацаатай, жилд X хувийн хүүтэй бөгөөд энэ нь засгийн газрын одоогийн зээлийн хүүний түвшин юм.

Засгийн газрын гишүүн ноён D ба E нарын цалингийн багц нь тэднийг машин худалдан авахад зориулан жилийн Y хувийн хүүтэйгээр A хүртэлх жилийн хугацаатай, засгийн газрын зээл авах боломж олгодог.

**Эрх бүхий албан тушаалтан болон тэдний гэр бүлийн ойрын гишүүдэд олгосон бусад цалин урамшуулал ба нөхөн төлбөр (34(б) параграф)**

Засгийн газрын тодорхой агентлагуудад үзүүлсэн зөвлөх үйлчилгээний төлөө засгийн газрын гишүүдэд тухайн тайлант үеийн туршид нийт X дүн (мөнгөн нэгж) бүхий нөхөн төлбөр олгосон.

Засгийн газар нь эрх бүхий албан тушаалтнуудын гэр бүлийн ойрын гишүүдэд тухайн тайлант үеийн туршид нийт Y дүн (мөнгөн нэгж) бүхий цалин урамшуулал болон нөхөн төлбөр олгосон. Энэхүү дүн нь засгийн газрын гишүүдийн гэр бүлийн ойрын гишүүд болох засгийн газрын ажилтнуудын цалин урамшуулаас бүрдэж байна.

### **Тодруулга – Засгийн газрын “XYZ” агентлаг**

Тусдаа тайлагнагч байгууллага болох засгийн газрын “XYZ” агентлагийн санхүүгийн тайланд дараах тодруулгыг хийсэн.

*Хяналтанд буй байгууллага (25-р параграф)*

Тус агентлагийг “X” хэлтэс хянадаг. “X” хэлтсийг “X” засгийн газар хянадаг.

## ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА

Уг агентлаг нь улсын секторын худалдаа арилжааны байгууллага болох Захиргааны Үйлчилгээний Нэгжийг хянадаг.

(Жич: УСНББОУС 35 нь хяналтанд буй томоохон байгууллагуудын талаар зарим тодруулга хийхийг шаарддаг.)

### *Холбоотой талуудын ажил гүйлгээ (27-р параграф)*

Тус агентлаг нь нэг сайдад хаузыг түрээсийн төлбөргүйгээр олгосон. Энэ сайдад олгосонтой ижил хаузыг жилд ойролцоогоор Z мөнгөн нэгжээр түрээслэдэг. Хауз нь уг сайдад олгох цалин урамшууллын багцын бүрэлдэхүүн хэсэг биш бөгөөд засгийн газрын агентлагууд нь өөрийн үйл ажиллагааны горимын дагуу сайдуудыг орон байраар хангадаггүй. Гэвч энэ тохиолдолд уг сайдад хауз олгох хэрэгтэй гэж “X” засгийн газраас зөвлөсөн.

### *Эрх бүхий албан тушаалтан (34-р параграф)*

#### **Цалин урамшуулал (34(а) параграф)**

“XYZ” агентлагийн эрх бүхий албан тушаалтнууд (УСНББОУС 20-д тодорхойлсноор) нь уг сайд, удирдах зөвлөлийн гишүүд, дээд түвшний удирдлагын бүлгийн гишүүд юм. Удирдах зөвлөл нь “X” засгийн газрын томилсон гишүүдээс бүрддэг; гүйцэтгэх захирал болон санхүүгийн албаны дарга нь удирдах зөвлөлийн хуралд оролцдог боловч удирдах зөвлөлийн гишүүд биш юм. “XYZ” агентлаг нь сайдад цалин урамшуулал олгодоггүй. Удирдах зөвлөлийн гишүүдийн нийт цалин урамшуулал ба энэхүү ангиллын хүрээнд цалин урамшуулал авдаг, бүтэн цагтай адилтгах сууриар тодорхойлсон гишүүдийн тоо дараах байдалтай байна:

Нийт цалин урамшуулал	AX сая.
Хүмүүсийн тоо	AU хүн.

Дээд түвшний удирдлагын бүлэг нь уг агентлагийн гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга болон хэсгийн A, Z дарга нараас бүрддэг. Дээд түвшний удирдлагын бүлгийн гишүүдийн нийт цалин урамшуулал ба энэхүү ангиллын хүрээнд цалин урамшуулал авдаг, бүтэн цагтай адилтгах сууриар тодорхойлсон менежерүүдийн тоо дараах байдалтай байна:

Нийт цалин урамшуулал	AP сая.
Хүмүүсийн тоо	AQ хүн.

Хэсгийн хоёр дарга нь “X” хэлтсээс томилогдсон бөгөөд уг “X” хэлтэс нь тэдний цалин урамшууллыг олгодог.

**Дээд түвшний удирдлагын бүлэгт хамаарахгүй хүмүүст нийтлэг олгох боломжгүй (түүний олгогдох боломжийн талаар олон нийт ерөнхийдөө мэддэггүй) зээл (34(в) параграф)**

## ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ТОДРУУЛГА

Тайлант үеийн туршид авсан ба буцаан төлсөн ийм зээлийн дүн болон тухайн тайлант үеийн эцэс дэх төлөгдөөгүй үлдэгдлийг доор харуулав:

<u>Хувь хүн</u>	<u>Олгосон</u>	<u>Буцаан төлсөн</u>	<u>Үлдэгдэл</u>
Сайд	J	K	L
Ноён G	M	N	P
Хатагтай H	Q	R	Z

### **Хугацаа ба нөхцөл**

Сайд нь зах зээлийн хүүнийн түвшнээс Y хувиар бага буюу жилийн X хүүтэйгээр зээлийг авсан. Зээлийн хугацаа нь Z жил байна.

Удирдах албан тушаалтнууд болох ноён G ба хатагтай H нарын цалингийн багц нь тэднийг машин худалдан авахад зориулан жилийн Y хувийн хүүтэйгээр N хүртэлх жилийн хугацаатай, засгийн газрын зээл авах боломж олгодог.

### **Эрх бүхий албан тушаалтны гэр бүлийн ойрын гишүүдэд олгосон цалин урамшуулал ба нөхөн төлбөр (34(б) параграф)**

Тус агентлаг нь эрх бүхий албан тушаалтны гэр бүлийн ойрын гишүүд болох ажилтнуудад тухайн тайлант үеийн туршид нийт F дүн (мөнгөн нэгж) бүхий цалин урамшуулал болон нөхөн төлбөр олгосон.



## НББОУС 24-ТЭЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 20-ийг НББОУС 24 (1994 онд хянан засварласан)-ээс үндсэндээ бэлтгэсэн. УСНББОУС 20 ба НББОУС 24-ийн хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- УСНББОУС 20-ийн бүтэц нь НББОУС 24-өөс эрс ялгаатай байна.
- Толгой компани нь нэг ижил улс оронд байрладаг бөгөөд тэрхүү улсдаа нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэдэг тохиолдолд бүрэн өмчлөлт охин компанийг НББОУС 24-ийн цар хүрээнээс хасдагтай адил заалтыг УСНББОУС 20-д тусгаагүй.
- Эрх бүхий албан тушаалтныг НББОУС 24-д тодорхойлсон тайлбар заалтыг УСНББОУС 20 дахь “эрх бүхий албан тушаалтан” гэсэн албан ёсны тодорхойлолтонд тусган оруулсан. НББОУС 24 дэх уг тайлбар заалт нь гэр бүлийн ойрын гишүүдийг тусган агуулсан байдаг. Харин УСНББОУС 20 дахь “эрх бүхий албан тушаалтан” гэсэн тодорхойлолт нь гэр бүлийн ойрын гишүүдийг тусгаагүй байдаг.
- УСНББОУС 20 дахь “холбоотой тал” гэсэн тодорхойлолт нь НББОУС 24-ийн тайлбар заалтанд зөвхөн тэмдэглэсэн холбоотой талын харилцааг тусган агуулсан байдаг.
- УСНББОУС 20 нь “эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал” гэсэн тодорхойлолтыг тусгасан. Харин НББОУС 24-д ийм тодорхойлолт байдаггүй.
- УСНББОУС 20 нь дараах зүйлстэй холбоотой нэмэлт тодруулгын шаардлагуудыг агуулсан байдаг. Үүнд: (а) эрх бүхий албан тушаалтан ба тэдний гэр бүлийн ойрын гишүүдийн цалин урамшуулал, (б) байгууллага ба түүний эрх бүхий албан тушаалтан, түүнчлэн тэдний гэр бүлийн ойрын гишүүдийн хооронд хийгдсэн бусад зарим ажил гүйлгээ.
- Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал болон тэдгээртэй хийсэн бусад зарим тусгайлан заасан ажил гүйлгээний талаархи хязгаарлагдмал цөөн тодруулгаас өөр бусдаар УСНББОУС 20 нь холбоотой талуудын хооронд хэвийн арилжааны нөхцөл, болзлоор хийгдсэн ажил гүйлгээний талаархи мэдээллийн тодруулга хийхийг шаарддаггүй. Талуудын хооронд хэвийн арилжааны явцад хийгдсэн холбоотой талуудын ажил гүйлгээний хувьд НББОУС 24 нь харьцангуй цөөн чөлөөлөх нөхцлүүдтэй байдаг.
- УСНББОУС 20 нь зарим тохиолдолд НББОУС 24-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь УСНББОУС 20 дахь “удирдах зөвлөлийн гишүүд” гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. НББОУС 24 дэх адилтгах нэр томъёо нь “захирлууд” юм.

## УСНББОУС 21–МӨНГӨ БИЙ БОЛГОДОГГҮЙ ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) 36, *Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт* (2004)-аас үндсэндээ бэлтгэсэн болно. НББОУС 36-гаас авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон ЕС4М 6ХН, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)

Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.

## **УСНББОУС 21-МӨНГӨ БИЙ БОЛГОДОГГҮЙ ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ**

### **УСНББОУС-ын түүх**

*Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.*

УСНББОУС 21, *Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-ыг 2004 оны 12 дугаар сард гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 21-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл* (2017 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж* (2016 оны 7 дугаар сард гаргасан)
- *Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт* (УСНББОУС 21, *Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*, УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-ын нэмэлт өөрчлөлтүүд) (2016 оны 7 дугаар сард гаргасан)
- *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал* (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- *УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд* (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 37, *Хамтын Хэлэлцээр* (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан* (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх* (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- *УСНББОУС 2011-ийн Сайжруулалтууд* (2011 оны 10 дугаар сард гаргасан)
- УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт* (2008 оны 02 дугаар сард гаргасан)
- УСНББОУС 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт* (2010 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 31, *Биет Бус Хөрөнгө* (2010 оны 01 дүгээр сард гаргасан)
- *УСНББОУС-ын Сайжруулалтууд* (2010 оны 11 дүгээр сард гаргасан)

**УСНББОУС 21-ийн нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт**

<b>Өөрчлөгдсөн параграф</b>	<b>Хэрхэн өөрчилсөн</b>	<b>Юугаар өөрчилсөн</b>
2	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 29, 2010 оны 01-р сар УСНББОУС 31, 2010 оны 01-р сар Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт, 2016 оны 7-р сар
3	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
4	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
5	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 26, 2008 оны 02-р сар
6	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 26, 2008 оны 02-р сар УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
7	Хассан	Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт, 2016 оны 7-р сар
9	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 29, 2010 оны 01-р сар
11	Хассан	Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт, 2016 оны 7-р сар
12	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
13	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
14	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 26, 2008 оны 02-р сар УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
15	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
16 <sup>1</sup>	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 26, 2008 оны 02-р сар
17	Шинэ	УСНББОУС 26, 2008 оны 02-р сар
18	Шинэ	УСНББОУС 26, 2008 оны 02-р сар
19	Шинэ	УСНББОУС 26, 2008 оны 02-р сар
20	Шинэ	УСНББОУС 26, 2008 оны 02-р сар УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
20	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
20А	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
21	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
26А	Шинэ	УСНББОУС 31, 2010 оны 01-р сар

<sup>1</sup> Дараагийн параграфуудыг дахин дугаарласан.

МӨНГӨ БИЙ БОЛГОДОГҮЙ ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

26Б	Шинэ	УСНББОУС 31, 2010 оны 01-р сар
27	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
37	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
39А	Шинэ	УСНББОУС 31, 2010 оны 01-р сар
43	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 39, 2016 оны 7-р сар
54	Нэмэлт өөрчлөлт	Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт, 2016 оны 7-р сар
54А	Шинэ	Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт, 2016 оны 7-р сар
69	Нэмэлт өөрчлөлт	Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт, 2016 оны 7-р сар
69А	Шинэ	Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт, 2016 оны 7-р сар
71	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 26, 2008 оны 02-р сар
72	Шинэ	УСНББОУС 26, 2008 оны 02-р сар
72А	Шинэ	УСНББОУС 26, 2008 оны 02-р сар
73	Нэмэлт өөрчлөлт	Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт, 2016 оны 7-р сар
73А	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
73А	Хассан	Хянан найруулга, 2012 оны 4-р сар
80	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
80А	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
81	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
81А	Шинэ	Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт, 2016 оны 7-р сар
82А	Шинэ	УСНББОУС 31, 2010 оны 01-р сар
82Б	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
82В	Шинэ	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
82Г	Шинэ	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
82Д	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
82Е	Шинэ	Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт, 2016 оны 7-р сар
82Ж	Шинэ	УСНББОУС 39, 2016 оны 7-р сар
82И	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
83	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар

2004 оны 12 дугаар сар

**УСНББОУС 21–МӨНГӨ БИЙ БОЛГОДОГГҮЙ ХӨРӨНГИЙН ҮНЭ  
ЦЭНИЙН БУУРАЛТ**

**АГУУЛГА**

	Параграф
Зорилго	1
Цар хүрээ	2-13
Тодорхойлолт	14-23
Улсын Үйлдвэрийн Газар	15
Мөнгө бий болгогч хөрөнгө	16-21
Элэгдэл	22
Үнэ цэнийн бууралт	23
Үнэ цэнэ буурсан байж болох хөрөнгийг тодорхойлох	24-34
Нөхөгдөх үйлчилгээний дүнг хэмжих	35-50
Тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн нөхөгдөх үйлчилгээний дүнг хэмжих	39А
Борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ	40-43
Ашиглалтын үнэ цэнэ	44-49
Элэгдэл тооцсон орлуулалтын өртгийн хандлага	45-47
Нөхөн сэргээлтийн өртгийн хандлага	48
Үйлчилгээний нэгжийн хандлага	49
Хандлагуудын хэрэглээ	50
Үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөх ба хэмжих	51-57
Үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах	58-70
Хөрөнгийг дахин ангилах	71-72
Тодруулга	72А-79
Шилжилтийн нөхцөл	80-81
Хүчин төгөлдөр болох хугацаа	82-83
Дүгнэлтийн үндэслэл	
Хэрэгжүүлэх заавар удирдамж	
Үлгэрчилсэн жишээ	
НББОУС 36 (2004)-тай харьцуулалт	

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 21, *Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-ыг 1-83-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 21-ийг түүний зорилгын агуулга, Дүгнэлтийн Үндэслэл, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

1. Энэ Стандартын зорилго нь мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэхийг тогтоохын тулд байгууллагын мөрдөх горимуудыг тодорхойлох ба тэрхүү үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрсөн гэдгийг ханган магадлах явдал юм. Мөн энэ Стандарт нь үнэ цэнийн бууралтын гарзыг байгууллага хэзээ буцаахыг тусгайлан заадаг бөгөөд тодруулгыг тодорхойлдог.

## Цар хүрээ

2. **Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь доор дурдсанаас бусад, мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тайлагнахдаа энэ Стандартыг мөрдөнө.**
  - (а) **Бараа материал (УСНББОУС 12, *Бараа Материал*-ыг үзнэ үү);**
  - (б) **Барилгын гэрээнээс үүссэн хөрөнгө (УСНББОУС 11, *Барилгын гэрээ*-г үзнэ үү);**
  - (в) **УСНББОУС 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*-ийн цар хүрээнд хамаарах санхүүгийн хөрөнө;**
  - (г) **Бодит үнэ цэнийн загвар ашиглан хэмждэг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө (УСНББОУС 16, *Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө*-ийг үзнэ үү);**
  - (д) [Хассан]
  - (е) [Хассан]
  - (ж) **Үнэ цэнийн бууралтын талаархи нягтлан бодох бүртгэлийн шаардлагууд нь өөр УСНББОУС-д тусгагдсан бусад хөрөнгүүд.**
3. [Хассан]
4. [Хассан]
5. **14-р параграфт тодорхойлсончлон, мөнгө бий болгогч хөрөнгийг эзэмшдэг улсын секторын байгууллагууд нь ийм хөрөнгөндөө УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-ыг мөрдөнө. Мөнгө бий болгодоггүй хөрөнгийг эзэмшдэг улсын секторын байгууллага нь уг мөнгө бий болгодоггүй хөрөнгөндөө энэ Стандартын шаардлагуудыг мөрдөнө.**
6. Энэ Стандарт нь бусад УСНББОУС-д авч үзсэн хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралтыг өөрийн цар хүрээнд хамруулаагүй. Улсын секторын байгууллагууд нь өөрийн мөнгө бий болгогч хөрөнгөндөө УСНББОУС 26-г, харин мөнгө бий болгодоггүй хөрөнгөндөө энэ Стандартыг мөрдөнө. Энэ Стандартын цар хүрээг 6-13-р параграфт илүү дэлгэрэнгүй тайлбарласан.
7. [Хассан]



8. Бараа материал, барилгын гэрээнээс үүссэн хөрөнгөнд хамаарах, одоо оршин буй УСНББОУС-ууд нь эдгээр хөрөнгүүдийг хүлээн зөвшөөрөх ба хэмжих шаардлагуудыг өөртөө агуулсан байдаг тул тэдгээрийн хувьд энэ Стандартыг мөрдөхгүй.
9. УСНББОУС 28, *Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга*-ын цар хүрээнд хамаарах санхүүгийн хөрөнгийн хувьд энэ Стандартыг мөрдөхгүй. Эдгээр хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг УСНББОУС 29-д авч үзсэн.
10. Энэ Стандарт нь УСНББОУС 16-гийн дагуу бодит үнэ цэнээр бүртгэсэн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын сорил хийхийг шаарддаггүй. Яагаад гэвэл, УСНББОУС 16-д заасан бодит үнэ цэнийн загварын дагуу хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг тухайн тайлангийн өдрөөр бодит үнэ цэнээр бүртгэдэг бөгөөд аливаа үнэ цэнийн бууралтыг тэрхүү үнэлгээнд харгалзан тусгасан байдаг.
11. [Хассан]
12. Мөнгө бий болгогч хөрөнгө гэж ангилсан үндсэн хөрөнгийг, үүн дотроо УСНББОУС 17-гийн зөвшөөрөгдсөн сонголтот хувилбарын дагуу дахин үнэлсэн дүнгээр бүртгэсэн үндсэн хөрөнгийг дээрх 5-р параграфын шаардлагуудад нийцүүлэн УСНББОУС 26-гийн дагуу тайлагнана.
13. Дараах байгууллагуудад оруулсан хөрөнгө оруулалтууд нь УСНББОУС 29-ийн цар хүрээнд хамаарахгүй санхүүгийн хөрөнгүүд юм:
  - (а) УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*-д тодорхойлсон хяналтанд буй байгууллагууд;
  - (б) УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*-д тодорхойлсон хараат байгууллага;
  - (в) УСНББОУС 37, *Хамтын Хэлэлцээр*-т тодорхойлсон хамтын хэлэлцээр.

Ийм хөрөнгө оруулалтыг мөнгө бий болгогч хөрөнгө гэж ангилдаг бол түүнийг УСНББОУС 26-гийн дагуу тайлагнана. Харин эдгээр хөрөнгө оруулалт нь мөнгө бий болгодоггүй хөрөнгө бол тэдгээрийг энэ Стандартын дагуу тайлагнана.

## Тодорхойлолт

14. **Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:**

**Идэвхитэй зах зээл** гэдэг нь дараах бүх нөхцөл хангагдсан зах зээл юм:

- (а) **Тухайн зах зээлд арилждаг зүйлс нь ижил төсөөтэй;**

(б) Арилжаанд оролцоход бэлэн, худалдан авагч ба борлуулагчийг хүссэн үедээ ихэвчлэн олж чадах;

(в) Үнэ нь олон нийтэд нээлттэй, бэлэн байх.

Мөнгө бий болгогч хөрөнгө гэдэг нь худалдаа арилжааны өгөөж бий болгох үндсэн зорилготойгоор эзэмшиж буй хөрөнгө юм. Үнэ цэнийн бууралтын зорилгын хувьд гүүдвиллийг мөнгө бий болгогч хөрөнгө гэж үзнэ.

Данснаас хасах зардал гэдэг нь хөрөнгийн данснаас хасалтанд шууд хамаарах, өсөн нэмэгдэх зардал бөгөөд үүнд санхүүгийн зардал болон орлогын албан татварын зардал хамаарахгүй.

Борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ гэдэг нь зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хоорондох, харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгийг борлуулснаар олж авах ба түүний данснаас хасалтын зардлыг хассаны дараах дүн юм.

Үнэ цэнийн бууралт гэдэг нь хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн бууралтыг элэгдлээр дамжуулан системтэй хүлээн зөвшөөрөх дүнгээс илүү буюу өндрөөр тухайн хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхид учрах гарз юм.

Мөнгө бий болгодоггүй хөрөнгө гэдэг нь мөнгө бий болгогч хөрөнгөөс бусад хөрөнгө юм.

Нөхөгдөх үйлчилгээний дүн гэдэг нь мөнгө бий болгодоггүй хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ ба түүний ашиглалтын үнэ цэнийн аль өндөр нь юм.

Ашиглалтын хугацаа гэдэг нь:

(а) тухайн байгууллагад уг хөрөнгө ашиглагдахаар хүлээгдэж буй хугацаа; эсвэл

(б) байгууллага нь тухайн хөрөнгөөс олж авахаар хүлээж буй бүтээгдэхүүн буюу түүнтэй адилтгах нэгжүүдийн тоо хэмжээ.

Мөнгө бий болгодоггүй хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ гэдэг нь тухайн хөрөнгийн үлдсэн үйлчилгээний чадавхийн өнөөгийн үнэ цэнэ юм.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д дахин нийтэлсэн болно.

## Улсын Үйлдвэрийн Газар

15. [Хассан]

### Мөнгө бий болгогч хөрөнгө

16. Мөнгө бий болгогч хөрөнгө нь худалдаа арилжааны өгөөж бий болгох үндсэн зорилготойгоор эзэмшиж буй хөрөнгө юм. Ашгийн төлөө байгууллагын хэрэглэдэг арга маягтай нийцсэн байдлаар хөрөнгийг ашигладаг тохиолдолд хөрөнгө нь арилжааны үр өгөөж бий болгодог. Арилжааны үр өгөөж бий болгохын тулд хөрөнгийг эзэмших нь байгууллага уг хөрөнгөөс (эсвэл тухайн хөрөнгө түүний нэг хэсэг нь болдог мөнгө бий болгогч нэгжээс) эерэг мөнгөн орлогын гүйлгээ үүсгэх ба хөрөнгийг эзэмшихтэй холбоотой эрсдлийг тусгах тийм арилжааны үр өгөөж олох санаа бодолтой байгаа гэдгийг илэрхийлнэ. Хэдийгээр хөрөнгө нь арилжааны үр өгөөж бий болгох зорилтыг тухайн тайлант үеийн туршид ханган биелүүлээгүй боловч уг хөрөнгийг ийм үндсэн зорилготойгоор эзэмшдэг байж болно. Нөгөө талаас, хөрөнгө нь тухайн тайлант үеийн туршид ашиг, алдагдалгүй хугарлын цэг дээр байх буюу арилжааны үр өгөөж үүсгэсэн боловч мөнгө бий болгодоггүй хөрөнгө байж болох юм. Өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд энэ Стандартын дараах параграфууд дахь хөрөнгө буюу хөрөнгүүд гэсэн хэллэг нь мөнгө бий болгодоггүй хөрөнгө (хөрөнгүүд)-ийг илэрхийлнэ.
17. Улсын секторын байгууллагууд нь өөрийн ихэнх хөрөнгийг арилжааны үр өгөөж бий болгох зорилгоор эзэмшдэггүй боловч зарим хөрөнгийг ийм зорилгоор эзэмшиж болох олон нөхцөл байдал байдаг. Жишээлбэл; эмнэлэг нь төлбөртэй хэвтэн эмчлүүлэгчдэд зориулан барилгыг ашигладаг байж болно. Улсын секторын байгууллагын мөнгө бий болгогч хөрөнгүүд нь тухайн байгууллагын мөнгө бий болгодоггүй хөрөнгүүдээс хараат бусаар ажилладаг байж болох юм. Жишээлбэл; үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн алба нь газрын асуудал эрхэлсэн албанаас хараат бус газрын бүртгэлийн хураамжийг хүлээн авдаг байж болно.
18. Хөрөнгийг үндсэндээ үйлчилгээ үзүүлэх зорилгоор эзэмшдэг боловч зарим тохиолдолд хөрөнгө нь мөнгөн гүйлгээ үүсгэдэг байж болох юм. Жишээлбэл; хаягдал боловсруулах үйлдвэр нь төрийн өмчит эмнэлгүүдийн гаргасан эмнэлгийн хаягдлыг аюулгүй устгахын тулд үйл ажиллагаагаа явуулдаг боловч бусад хувийн эмнэлгийн багахан хэмжээний эмнэлгийн хаягдлыг мөн арилжааны сууриар боловсруулдаг. Хувийн эмнэлгүүдээс хүлээн авсан эмнэлгийн хаягдал боловсруулалт нь уг үйлдвэрийн үйл ажиллагаанд туслах шинж чанартай бөгөөд уг мөнгөн орлого бий болгож буй хөрөнгүүдийг мөнгө бий болгодоггүй хөрөнгүүдээс ялган зааглах боломжгүй байдаг.
19. Өөр зарим тохиолдолд хөрөнгө нь мөнгөн гүйлгээг бий болгодог бөгөөд мөнгө бий болгодоггүй зорилгод түүнийг бас ашигладаг байж болох юм. Жишээлбэл; улсын эмнэлэг нь арван тасагтай бөгөөд тэдгээрийн есийг нь төлбөртэй хэвтэн эмчлүүлэгчдэд зориулан арилжааны сууриар

ашигладаг. Харин нэгийг нь төлбөргүй хэвтэн эмчлүүлэгчдэд зориулан ашигладаг. Төлбөртэй ба төлбөргүй тасгуудын аль алины хэвтэн эмчлүүлэгчид нь эмнэлгийн бусад төхөөрөмж хэрэгслийг (тухайлбал, мэс заслын төхөөрөмж) хамтдаа ашигладаг. Уг байгууллага нь энэ Стандартын эсвэл УСНББОУС 26-гийн заалтуудыг мөрдөх хэрэгтэй эсэхийг тодорхойлохын тулд арилжааны үр өгөөж бий болгох зорилгоор тухайн хөрөнгийг эзэмшиж буй хэмжээг харгалзан үзэх шаардлагатай. Энэ жишээнд дурдсантай адилаар, мөнгө бий болгодоггүй хэсэг нь нийт үйл ажиллагааны хувьд мэдэгдэхүйц бус хэмжээтэй бол тухайн байгууллага нь энэ Стандартыг биш, харин УСНББОУС 26-г мөрдөнө.

20. Зарим тохиолдолд хөрөнгийг эзэмшиж буй үндсэн зорилго нь арилжааны үр өгөөж бий болгох эсэх нь тодорхой бус байж болох юм. Ийм тохиолдолд тухайн мөнгөн гүйлгээний ач холбогдлыг үнэлэх шаардлагатай байдаг. Мөнгөн гүйлгээг бий болгож буй тухайн хөрөнгө нь УСНББОУС 26-г биш, харин энэ Стандартыг мөрдөхөд хүргэхүйц маш мэдэгдэхүйц хэмжээтэй эсэхийг тодорхойлоход төвөгтэй байж болох юм. Аль стандартыг мөрдөх эсэхийг тодорхойлохдоо шүүн тунгаалт хийх шаардлагатай. Мөнгө бий болгогч хөрөнгө болон мөнгө бий болгодоггүй хөрөнгийн тодорхойлолт, түүнчлэн 16-20-р параграфын холбогдох заавар удирдамжинд нийцүүлэн шүүн тунгаалтыг хийхийн тулд байгууллага нь шалгуурыг боловсруулдаг. Байгууллага нь ийм шүүн тунгаалт хийхдээ ашигласан шалгуураа тодруулахыг 73А параграфтаар шаардсан байдаг. Гэвч улсын секторын ихэнх байгууллагуудын ерөнхий зорилгыг харгалзан үзвэл, тэдгээр хөрөнгө нь мөнгө бий болгодоггүй хөрөнгө байх бөгөөд иймээс УСНББОУС 21-ийг мөрдөнө гэсэн урьдчилсан төсөөлөлтэй байдаг.
- 20А Үнэ цэнийн бууралтын зорилгын хувьд гүүдвиллийг мөнгө бий болгогч хөрөнгө гэж үздэг. Гүүдвилл нь бусад хөрөнгүүдээс бие даасан байдлаар эдийн засгийн үр өгөөжийг бий болгодоггүй бөгөөд түүний үнэ цэнийн бууралтыг бусад хөрөнгүүдийн бүлгийн нэг хэсэг байдлаар үнэлдэг. Бие даасан хөрөнгүүдийн үнэлгээг энэ Стандартад авч үзнэ. Гүүдвилл нь мөнгөн орлогын гүйлгээ үүсэх эсвэл нэгтгэгчийн цэвэр мөнгөн зарлагыг бууруулах үр дүнтэй зөвхөн тохиолдолд түүнийг хүлээн зөвшөөрнө. Холбогдох мөнгөн гүйлгээг бий болгохгүй үйлчилгээний чадавхийн хувьд гүүдвиллийг хүлээн зөвшөөрөхгүй. Үнэ цэнийн бууралтыг үнэлэхийн тулд энэ Стандартад ашигласан нөхөгдөх үйлчилгээний дүнд үйлчилгээний чадавхи хамаарна. Иймээс байгууллага нь гүүдвиллийн үнэ цэнийг бууруулах эсэхийг тодорхойлохын тулд энэ Стандартыг биш, харин УСНББОУС 26-г мөрдөнө.
21. Улсын секторын худалдаа арилжааны байгууллагуудын эзэмшиж буй хөрөнгө нь мөнгө бий болгогч хөрөнгө байдаг. Улсын секторын байгууллагууд нь арилжааны өгөөж бий болгохын тулд хөрөнгийг эзэмшиж болох юм. Гадны талуудад бараа, үйлчилгээг нийлүүлснээр арилжааны өгөөж бий болгох зорилгоор хөрөнгийг (эсвэл тухайн хөрөнгө нэг хэсэг нь болох мөнгө бий болгогч нэгжийг) ашиглан ажиллуулдаг бол

## МӨНГӨ БИЙ БОЛГОДОГГҮЙ ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

уг улсын секторын байгууллагын эзэмшиж буй хөрөнгийг энэ Стандартын зорилгын хувьд мөнгө бий болгогч хөрөнгө гэж ангилна.

### Элэгдэл

22. Элэгдэл ба хорогдуулга нь хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид хуваарилах системтэй хуваарилалт юм. Биет бус хөрөнгийн хувьд “элэгдэл” гэдгийн оронд “хорогдуулга” гэсэн нэр томъёог ихэвчлэн ашигладаг. Эдгээр нэр томъёо нь ижил утгатай юм.

### Үнэ цэнийн бууралт

23. Үнэ цэнийн бууралт нь хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн бууралтыг элэгдлээр (хорогдуулгаар) дамжуулан системтэй хүлээн зөвшөөрөх дүнгээс илүү буюу өндрөөр тухайн хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхид учрах гарз гэж энэ Стандартад тодорхойлдог. Иймээс үнэ цэнийн бууралт нь тухайн хөрөнгийг хянаж буй байгууллага дахь түүний хэрэгцээт чанарын бууралтыг тусган илэрхийлдэг. Жишээлбэл; байгууллага нь цаашид ашиглагдахгүй болсон бөгөөд цэргийн зориулалтаар барьсан агуулахтай байж болох юм. Түүнчлэн уг байгууламжийн тусгай шинж чанар ба байршлаас хамааран түүнийг түрээслэх буюу борлуулах магадлал багатай байна. Иймээс байгууллага нь уг хөрөнгийг түрээслэх буюу худалдан борлуулснаар мөнгөн орлогын гүйлгээ бий болгох боломжгүй юм. Тухайн хөрөнгө нь байгууллагад үйлчилгээний чадавхи цаашид бий болгож чадахгүй, өөрөөр хэлбэл өөрийн зорилтуудад хүрэхэд уг байгууллагад хувь нэмрээ оруулах хэрэгцээт чанар багатай буюу байхгүй учраас түүний үнэ цэнэ буурсан гэж үзнэ.

### Үнэ цэнэ буурсан байж болох хөрөнгийг тодорхойлох

24. Нөхөгдөх үйлчилгээний дүнг хэзээ тодорхойлохыг 26-34-р параграфт тусгайлан заасан.
25. Мөнгө бий болгодоггүй хөрөнгийн дансны үнэ нь түүний нөхөгдөх үйлчилгээний дүнгээс давсан тохиолдолд уг хөрөнгийн үнэ цэнэ буурсан байдаг. Үнэ цэнийн бууралтын гарз үүссэн байж болох гол шинжүүдийг 27-р параграфт тодорхойлсон. Хэрэв эдгээр шинжүүдийн аль нэг нь илэрсэн бол байгууллага нь нөхөгдөх үйлчилгээний дүнгийн талаар албан ёсны тооцоолол хийх шаардлагатай байдаг. Боломжит үнэ цэнийн бууралтын гарзын шинж тэмдэг илрээгүй бол байгууллага нь нөхөгдөх үйлчилгээний дүнгийн талаар албан ёсны тооцоолол хийхийг энэ Стандартаар шаардахгүй.
26. **Байгууллага нь хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болох ямар нэг шинж тэмдэг байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст үнэлнэ. Хэрэв ийм ямар нэг шинж тэмдэг илэрвэл байгууллага нь тухайн хөрөнгийн нөхөгдөх үйлчилгээний дүнг тооцоолно.**

- 26А. Үнэ цэнийн бууралтын ямар нэг шинж тэмдэг байгаа эсэхээс үл хамааран байгууллага нь тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгө эсвэл ашиглахад хараахан бэлэн болоогүй биет бус хөрөнгийн дансны үнийг түүний нөхөгдөх үйлчилгээний дүнтэй зэрэгцүүлснээр үнэ цэнийн бууралтыг мөн жил бүр сорьж шалгана. Хэрэв энэхүү үнэ цэнийн бууралтын сорилыг жил бүрийн нэг ижил хугацаанд хийдэг бол жилийн турш дахь дурын хугацаанд үүнийг гүйцэтгэж болно. Харин өөр өөр биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг өөр өөр хугацаанд сорьж шалгаж болно. Гэхдээ ийм биет бус хөрөнгийг тайлант жилийн дундуур анх хүлээн зөвшөөрсөн бол тэрхүү биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тухайн тайлант жилийн эцэс болохоос өмнө сорьж шалгана.
- 26Б. Өөрийн дансны үнийг нөхөхүйц ирээдүйн хангалттай эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг бий болгох уг биет бус хөрөнгийн чадвар боломж нь ашиглахад бэлэн болсны дараах үетэй харьцуулахад ашиглахад хараахан бэлэн болоогүй байх үедээ ихэвчлэн маш тодорхойгүй байдаг. Иймээс энэхүү Стандарт нь ашиглахад хараахан бэлэн болоогүй байгаа биет бус хөрөнгийн дансны үнийн хувьд үнэ цэнийн бууралтыг наад зах нь жил бүр сорьж шалгаж байхыг байгууллагаас шаарддаг.
27. Хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болох ямар нэг шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлэхдээ, байгууллага хамгийн наад зах нь дараах шинж тэмдгийг харгалзан үзнэ:

**Мэдээллийн гадаад эх сурвалж**

- (а) Тухайн хөрөнгөөр үзүүлэх үйлчилгээний эрэлт буюу хэрэгцээ шаардлага нь зогссон буюу бараг зогссон;
- (б) Уг байгууллагад сөрөг нөлөөтэй урт хугацааны мэдэгдэхүйц өөрчлөлтүүд нь тэрхүү байгууллагын үйл ажиллагаа явуулдаг технологийн, хуулийн буюу засгийн газрын бодлогын орчинд тухайн тайлант үеийн туршид гарч тохиолдсон эсвэл ойрын ирээдүйд гарч тохиолдохоор байх;

**Мэдээллийн дотоод эх сурвалж**

- (в) Хөрөнгийн биет эвдрэл, гэмтлийн талаархи нотолгоо байх;
- (г) Уг байгууллагад сөрөг нөлөөтэй урт хугацааны мэдэгдэхүйц өөрчлөлтүүд нь түүний хөрөнгөө ашиглаж байгаа эсвэл ашиглахаар хүлээгдэж буй хэмжээ, арга маягт тухайн тайлант үеийн туршид гарч тохиолдсон эсвэл ойрын ирээдүйд гарахаар хүлээгдэж байх. Хөрөнгийн ашиглалтгүй сул зогсолт, тэрхүү хөрөнгөнд хамааралтай үйл ажиллагааг зогсоох буюу бүтцийн өөрчлөлт хийх төлөвлөгөө, анхны хүлээгдэж байсан өдрөөс өмнө хөрөнгийг данснаас хасах төлөвлөгөө, хөрөнгийн ашиглагдах хугацаа тодорхойгүй байсныг тодорхой

**хязгаарлагдмал болгосон дахин үнэлэлт зэрэг нь ийм өөрчлөлтөнд хамаарна.**

- (д) **Хөрөнгийг барьж байгуулах ажил дуусахаас эсвэл ашиглахад бэлэн болгохоос өмнө уг барилгын ажлыг зогсоох шийдвэр.**
  - (е) **Хөрөнгийн үйлчилгээний гүйцэтгэл, үр дүн нь хүлээгдэж байснаас мэдэгдэхүйц муу байх эсвэл муу болно гэдгийг илтгэсэн нотолгоо дотоод тайлагналаас бий болсон байх.**
28. Үйлчилгээний эрэлт буюу хэрэгцээ шаардлага нь тухайн үйлчилгээг үзүүлэхдээ уг мөнгө бий болгодоггүй хөрөнгийг ашиглах хэмжээнд нөлөө үзүүлэх байдлаар цаг хугацааны явцад хувьсан өөрчлөгдөж болох боловч эрэлтийн ийм сөрөг хувьсан өөрчлөлт нь заавал үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг байх албагүй юм. Үйлчилгээний эрэлт зогссон буюу бараг зогссон тохиолдолд тэрхүү үйлчилгээг үзүүлэхдээ ашигладаг хөрөнгийн үнэ цэнэ буурч болох юм. Байгууллага нь (а) тэрхүү эрэлтийн өөрчлөлтөнд хариу үзүүлэхийг эрмэлзэхгүй, эсвэл (б) үнэ цэнийн бууралтын сорилтонд харгалзан үзэж буй тухайн хөрөнгийг олж эзэмшихгүйгээр эрэлтийн өөрчлөлтөнд хариу үзүүлэх байдлаар эрэлт нь тийм бага болсон тохиолдолд эрэлт бараг зогссон гэж үзэж болох юм.
29. 27-р параграф дахь жагсаалтанд бүгдийг багтаагаагүй болно. Хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болохыг илтгэх бусад шинж тэмдгүүд байж болох юм. Ийм бусад шинж тэмдгүүд оршин байх нь тухайн хөрөнгийн нөхөгдөх үйлчилгээний дүнг байгууллага тооцоолоход хүргэж болно. Тухайлбал; дараах зүйлсийн аль нэг нь үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг байж болно:
- (а) Тухайн тайлант үеийн туршид хөрөнгийн зах зээлийн үнэ цэнэ нь цаг хугацаа урсан өнгөрөлт буюу хэвийн ашиглалтын үр дүнд хүлээгдэж болох хэмжээнээс мэдэгдэхүйц ихээр буурсан; эсвэл
  - (б) Уг хөрөнгөөр үзүүлэх үйлчилгээний эрэлт буюу хэрэгцээ шаардлагад урт хугацааны мэдэгдэхүйц бууралт гарсан (гэхдээ заавал үйлчилгээний зогсолт буюу бараг зогсолт байх албагүй юм).
30. Хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг илэрхийлж болох үйл явдал буюу нөхцөл байдал нь чухал ач холбогдолтой бөгөөд удирдах зөвлөл, удирдлага буюу хэвлэл мэдээллийн хэлэлцүүлэг хийхэд ямагт хүргэдэг. Үйлчилгээний эрэлт, ашиглалтын хэмжээ буюу арга маяг, эрх зүйн орчин буюу засгийн газрын бодлогын орчин зэрэг параметруудийн өөрчлөлт нь мэдэгдэхүйц хэмжээтэй бөгөөд урт хугацааны сөрөг нөлөө үзүүлэхээр байх зөвхөн тийм тохиолдолд уг өөрчлөлт нь үнэ цэнийн бууралтыг илэрхийлнэ. Технологийн орчны өөрчлөлт нь тухайн хөрөнгө хуучирч хоцрогдсон гэдгийг илэрхийлж болох бөгөөд үнэ цэнийн бууралтын сорил хийхийг шаарддаг. Тухайн тайлант үеийн туршид хөрөнгийн ашиглалтанд гарсан өөрчлөлт нь мөн үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг байж болно. Жишээлбэл; хичээл сургуулийн зориулалтаар ашиглаж байсан барилгын ашиглалтыг өөрчилж, түүнийг агуулах байдлаар ашиглахаар болсон үед ийм тохиолдол үүсэж болно. Үнэ цэнийн бууралт гарсан эсэхийг

үнэлэхдээ тухайн байгууллага нь үйлчилгээний чадавхид урт хугацаанд гарах өөрчлөлтийг үнэлэх шаардлагатай байдаг. Энэ нь хөрөнгийн урьдчилан төсөөлсөн урт хугацааны ашиглалтын хүрээнд тухайн өөрчлөлтийг харгалзан үзнэ гэдгийг илэрхийлдэг. Гэвч урт хугацааны ашиглалтын хүлээлт нь өөрчлөгдөж болох бөгөөд тайлант үе бүрийн эцэст хийгдэх уг байгууллагын үнэлгээнд үүнийг харгалзан тусгана. 27-р параграфт дурдсан үнэ цэнийн бууралтын шинж тэмдгүүдийн жишээг Хэрэгжүүлэх Заавар Удирдамжинд харуулсан.

31. Барилгын ажлыг зогсоох нь үнэ цэнийн бууралтын сорил хийхэд хүргэх эсэхийг үнэлэхдээ тухайн байгууллага нь (а) уг барилгын ажил зүгээр хугацаа хоцорсон буюу хойшлогдсон, (б) барилгын ажлыг ойрын ирээдүйд дахин эхлүүлэх төлөвлөгөөтэй байгаа эсэх, эсвэл (в) барилгын ажил нь урьдчилан харж болох ойрын ирээдүйд дуусахгүй эсэхийг харгалзан үзнэ. Барилгын ажлыг ирээдүйн тодорхой хугацаа хүртэл түр хойшлуулсан буюу хугацаа хоцорсон тохиолдолд уг төслийг дуусаагүй барилгатай адилтган авч үзэж болох бөгөөд зогсоосон гэж үзэхгүй.
32. Дээрх 27(е) параграфт дурдсанчлан, хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болохыг илтгэн харуулах дотоод тайлагналын нотолгоо нь тухайн хөрөнгөөр нийлүүлэх бараа, үйлчилгээний эрэлтийн бууралтыг биш, харин бараа, үйлчилгээ нийлүүлэх уг хөрөнгийн чадвар боломжтой холбоотой байдаг. Үүнд дараах зүйлсийн оршин байдал хамаарна:
- (а) Анхны төсөвлөсөн дүнтэй харьцуулахад тухайн хөрөнгийг ажиллуулах буюу хэвийн ажиллагааг хангахад мэдэгдэхүйц өндөр зардалтай байх;
  - (б) Үйл ажиллагааны гүйцэтгэл муу байсны улмаас анх хүлээгдэж байсантай харьцуулахад тухайн хөрөнгөөр үзүүлэх үйлчилгээ буюу нийлүүлэх гарц бүтээгдэхүүн мэдэгдэхүйц багассан байх.

Үйл ажиллагааны төсөв бэлтгэлтийн дагуу тухайн хөрөнгийн ажиллагааны зардалд гарсан мэдэгдэхүйц өсөлт нь үйлдвэрлэгчийн тогтоосон гарц бүтээгдэхүүний стандартад анх заасантай адилаар уг хөрөнгө үр ашигтай буюу бүтээмжтэй ажиллахгүй гэдгийг илэрхийлж болох юм. Үүнтэй адилаар, засвар үйлчилгээний зардлын мэдэгдэхүйц өсөлт нь түүний гүйцэтгэлийн хамгийн сүүлийн үеийн үнэлсэн стандартаар заасан түвшинд уг хөрөнгийн гүйцэтгэлийг хадгалахын тулд илүү өндөр зардал гаргах шаардлагатайг илэрхийлж болно. Зарим тохиолдолд, тухайн хөрөнгөөр үзүүлэх хүлээгдэж буй үйлчилгээ буюу нийлүүлэх гарц бүтээгдэхүүний урт хугацааны мэдэгдэхүйц бууралт нь үнэ цэнийн бууралтын талаархи шууд тоон нотолгоог хангаж болох юм.

33. Хөрөнгийн нөхөгдөх үйлчилгээний дүнг тооцоолох шаардлагатай эсэхийг тогтоохдоо материаллаг байдлын ойлголт ухагдахууныг ашигладаг. Жишээлбэл; хөрөнгийн нөхөгдөх үйлчилгээний дүн нь түүний дансны үнээс мэдэгдэхүйц илүү гэдгийг өмнөх үнэлгээгээр харуулсан тохиолдолд энэхүү зөрүүг арилгах ямар нэг үйл явдал гарч тохиолдоогүй бол тухайн байгууллага нь хөрөнгийн нөхөгдөх үйлчилгээний дүнг дахин тооцоолох



шаардлагагүй байдаг. Үүнтэй адилаар, хөрөнгийн нөхөгдөх үйлчилгээний дүн нь 27-р параграфт дурдсан шинж тэмдгүүдийн аль нэгнээс (буюу хэд хэдээс) хамааралгүй гэдгийг өмнөх шинжилгээгээр харуулж болох юм.

34. Хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болох шинж тэмдэг байгаа бол хэдийгээр уг хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөөгүй боловч энэ нь (а) хөрөнгийн ашиглалтын үлдсэн хугацаа, (б) элэгдлийн (хорогдуулгын) арга, (в) хөрөнгийн үлдэх өртгийг дахин хянан үзэж, тухайн хөрөнгөнд хамаарах Стандартын дагуу тохируулах шаардлагатай гэдгийг илэрхийлж болох юм.

### **Нөхөгдөх үйлчилгээний дүнг хэмжих**

35. Энэ Стандарт нь хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ ба түүний ашиглалтын үнэ цэнийн аль өндрөөр нөхөгдөх үйлчилгээний дүнг тодорхойлдог. Нөхөгдөх үйлчилгээний дүнг хэмжих сууриудыг 36-50-р параграфт заасан.
36. Хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ ба түүний ашиглалтын үнэ цэнийн аль алиныг байнга тодорхойлох шаардлагагүй байдаг. Хэрэв эдгээр дүнгүүдийн аль нэг нь тухайн хөрөнгийн дансны үнээс илүү байвал хөрөнгийн үнэ цэнэ буураагүй бөгөөд нөгөө дүнг тооцоолох шаардлагагүй юм.
37. Хөрөнгийг идэвхитэй зах зээлд арилждаггүй боловч түүний борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийг тооцоолох боломжтой байж болно. Хөрөнгийн идэвхитэй зах зээл оршин байхгүй тохиолдолд борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийг тооцоолох боломжит хувилбар сууриудыг 42-р параграфт заасан. Гэвч зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хоорондох харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгийг борлуулснаар олж авч болох дүнгийн талаар найдвартай<sup>2</sup> тооцоолол хийх суурь үндэслэл байхгүйн улмаас борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийг зарим үед тодорхойлох боломжгүй байдаг. Энэ тохиолдолд байгууллага нь хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг түүний нөхөгдөх дүн байдлаар ашиглаж болно.
38. Хэрэв хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ нь түүний борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээс материаллагаар илүү гэж үзэх шалтгаан үндэслэл байхгүй бол тухайн хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийг түүний нөхөгдөх дүн байдлаар ашиглаж болно. Данснаас хасах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийн хувьд ийм тохиолдол байнга гардаг. Яагаад гэвэл, данснаас хасах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ нь үндсэндээ түүний данснаас хасалтын цэвэр

---

<sup>2</sup> Найдвартай мэдээлэл нь материаллаг алдаа ба туйлшралаас ангид байх бөгөөд өөрийн илэрхийлэхээр зориулагдсан буюу илэрхийлнэ гэж үл үндэслэлтэйгээр хүлээж болох зүйлсийг үнэн зөв илэрхийлэхдээ хэрэглэгчдээс хамаардаг байж болох юм. Найдвартай байдлын тайлбарын талаархи шилжилтийн арга хандлагыг УСНББОУС 1-ийн ДҮ16-р параграфт авч хэлэлцсэн.

орлогоос бүрддэг. Гэвч нийгэмд тусгай үйлчилгээ үзүүлэх буюу нийтийн зориулалттай бараа нийлүүлэхийн тулд байнга тасралтгүй эзэмшиж буй улсын секторын мөнгө бий болгодоггүй олон хөрөнгийн хувьд, тэрхүү хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ нь түүний борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээс илүү байх магадлалтай юм.

39. Зарим тохиолдолд тооцоолол, дундаж дүн, хялбарчилсан тооцоолол нь борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ эсвэл ашиглалтын үнэ цэнийг тодорхойлохын тулд энэ Стандартад үлгэрчлэн харуулсан, дэлгэрэнгүй тооцооллын боломжит ойролцоо дүнг илэрхийлж болох юм.

**Тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн нөхөгдөх үйлчилгээний дүнг хэмжих**

- 39A. 26-р параграф нь үнэ цэнэ буурсан байж болох ямар нэг шинж тэмдэг байгаа эсэхээс үл хамааран тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн дансны үнийг түүний нөхөгдөх үйлчилгээний дүнтэй зэрэгцүүлснээр үнэ цэнийн бууралтыг жил бүр сорьж шалгахыг шаарддаг. Гэвч дараах бүх шалгуур хангагдаж байвал өмнөх тайлант үед хийсэн, ийм хөрөнгийн нөхөгдөх үйлчилгээний дүнгийн талаархи хамгийн сүүлийн дэлгэрэнгүй тооцооллыг тухайн тайлант үед уг хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сорилд хэрэглэж болно:

- (a) Биет бус хөрөнгө нь бусад хөрөнгө буюу хөрөнгүүдийн бүлгийн үйлчилгээний чадавхиас бүрэн хамааралгүй байдлаар өөрийн тасралтгүй ашиглалтаас үйлчилгээний чадавхийг бий болгож чадахгүй, иймээс түүний харъяалагдах мөнгө бий болгогч нэгжийн нэг хэсэг байдлаар уг биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг сорьж шалгадаг бөгөөд тухайн мөнгө бий болгогч нэгжийг бүрдүүлж буй хөрөнгө, өр төлбөр нь нөхөгдөх дүнгийн хамгийн сүүлийн тооцооллоос хойш мэдэгдэхүйц өөрчлөгдөөгүй;
- (б) Нөхөгдөх үйлчилгээний дүнгийн хамгийн сүүлийн тооцоолол нь тухайн хөрөнгийн дансны үнээс давсан мэдэгдэхүйц өндөр ашгийг харуулсан; ба
- (в) Нөхөгдөх үйлчилгээний дүнгийн хамгийн сүүлийн тооцооллоос хойш гарч тохиолдсон үйл явдлууд болон өөрчлөгдсөн нөхцөл байдлын шинжилгээнд үндэслэн авч үзэхэд одоогийн нөхөгдөх үйлчилгээний дүн нь тухайн хөрөнгийн дансны үнээс бага болох магадлал маш бага байх.

**Борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ**

40. Хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо нь уг хөрөнгийн данснаас хасалтанд шууд хамааруулж болох өсөн нэмэгдэх зардлын хувьд тохируулга хийсэн, харилцан хамааралгүй талуудын хоорондох ажил гүйлгээний заавал биелүүлэх борлуулалтын гэрээний үнэ юм.

41. Заавал биелүүлэх борлуулалтын гэрээ байхгүй боловч хөрөнгийг идэвхитэй зах зээлд арилждаг бол борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ нь тухайн хөрөнгийн зах зээлийн үнээс түүний данснаас хасалтын зардлыг хассан дүн байна. Зохих зах зээлийн үнэ нь ихэвчлэн одоогийн өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын үнэ байдаг. Одоогийн өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын үнэ нь бэлэн боломжтой байхгүй тохиолдолд уг ажил гүйлгээний өдөр ба тэрхүү тооцооллыг хийсэн өдрийн хоорондох хугацаанд эдийн засгийн нөхцөл байдалд мэдэгдэхүйц өөрчлөлт ороогүй бол хамгийн сүүлийн ажил гүйлгээний үнэ нь борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийг тооцоолох суурь үндэслэлээр хангаж болох юм.
42. Заавал биелүүлэх борлуулалтын гэрээ эсвэл хөрөнгийн идэвхитэй зах зээл байхгүй бол борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ нь бэлэн байгаа хамгийн сайн мэдээлэлд үндэслэдэг. Энэ мэдээлэл нь зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хоорондох харилцан хамааралгүй ажил гүйлгээгээр хөрөнгийг данснаас хассанаар уг тайлангийн өдөр тухайн байгууллагын олж авч чадах дүнгээс данснаас хасалтын зардлыг хассан дүнг тусгах бэлэн боломжтой байгаа хамгийн сайн мэдээлэлд үндэслэдэг. Энэхүү дүнг тодорхойлохдоо байгууллага нь тухайн салбар дахь ижил төсөөтэй хөрөнгүүдийн хамгийн сүүлийн үеийн ажил гүйлгээний үр дүнгүүдийг харгалзан үзэж болох юм. Удирдлага буюу удирдах зөвлөл нь нэн даруй борлуулалт хийх шахалтанд орсноос бусад тохиолдолд борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ нь албадан борлуулалтыг тусган илэрхийлдэггүй.
43. Борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийг хэмжихдээ, өр төлбөр гэж хүлээн зөвшөөрснөөс бусад, данснаас хасалтын өртөг зардлыг хасаж тооцно. Ийм өртөг зардлын жишээнд хуулийн үйлчилгээний зардал, тэмдэгтийн хураамж болон түүнтэй адилтгах ажил гүйлгээний татвар, хөрөнгийг нүүлгэн шилжүүлэх зардал, хөрөнгийг түүний борлуулах нөхцөл байдалд оруулахтай холбоотойгоор гарсан өсөн нэмэгдэх шууд зардал хамаарна. Харин ажлаас халагдалтын тэтгэмж (УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-д тодорхойлсон) болон хөрөнгийн данснаас хасалтын дараа бизнесийг хумих буюу бүтцийн өөрчлөлттэй холбоотой өртөг зардал нь тухайн хөрөнгийн данснаас хасалтын өсөн нэмэгдэх шууд зардал биш юм.

#### **Ашиглалтын үнэ цэнэ**

44. Энэ Стандарт нь мөнгө бий болгодоггүй хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг тухайн хөрөнгийн үлдсэн үйлчилгээний чадавхийн өнөөгийн үнэ цэнэ гэж тодорхойлдог. Энэ Стандарт дахь ашиглалтын үнэ цэнэ гэсэн хэллэг нь өөрөөр зааснаас бусад тохиолдолд мөнгө бий болгодоггүй хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг илэрхийлнэ. 45-49-р параграфт дурдсан хандлагуудын аль тохиромжтой нэгийг ашигласнаар тухайн хөрөнгийн үлдсэн үйлчилгээний чадавхийн өнөөгийн үнэ цэнийг тодорхойлдог.

*Элэгдэл тооцсон орлуулалтын өртгийн хандлага*

45. Энэ хандлагын дагуу хөрөнгийн үлдсэн үйлчилгээний чадавхийн өнөөгийн үнэ цэнийг тухайн хөрөнгийн элэгдэл тооцсон орлуулалтын өртөг байдлаар тодорхойлдог. Хөрөнгийн орлуулалтын өртөг нь тухайн хөрөнгийн нийт үйлчилгээний чадавхийг орлуулах өртөг зардал юм. Хөрөнгийн ашиглагдсан нөхцөл байдлыг тусгахын тулд энэхүү өртгийг элэгдүүлдж бууруулдаг. Одоо байгаа хөрөнгийг дахин үйлдвэрлэснээр (олшруулах) эсвэл түүний нийт үйлчилгээний чадавхийг орлуулснаар хөрөнгийг сольж орлуулж болох юм. Элэгдэл тооцсон орлуулалтын өртгийг тухайн хөрөнгийн дахин үйлдвэрлэлийн өртөг эсвэл орлуулалтын өртгийн аль багаар хэмжих бөгөөд тэрхүү хөрөнгийн нэгэнт ашиглан зарцуулсан буюу хугацаа дууссан үйлчилгээний чадавхийг тусгахын тулд уг өртөгт үндэслэн тооцоолсон, хуримтлагдсан элэгдлийг өртгөөс хасдаг.
46. Хөрөнгийн орлуулалтын өртөг ба дахин үйлдвэрлэлийн өртгийг оновчтой сууриар тодорхойлдог. Хэрэв сольж орлуулах буюу дахин үйлдвэрлэх хөрөнгө нь илүү загварлаг буюу илүү хүчин чадалтай бол ийм хөрөнгөөр уг байгууллага нь өөрийн тэрхүү хөрөнгийг сольж орлуулахгүй буюу дахин үйлдвэрлэхгүй гэсэн шалтгаан үндэслэлтэй байдаг. Илүү загварлаг хөрөнгө нь тухайн хөрөнгөөр нийлүүлэх бараа буюу үзүүлэх үйлчилгээний хувьд шаардлагагүй тийм шинж чанаруудыг агуулсан байдаг. Илүү хүчин чадалтай хөрөнгө нь тухайн хөрөнгөөр нийлүүлэх бараа буюу үзүүлэх үйлчилгээний эрэлтийг хангахад шаардлагатай хэмжээнээс илүү хүчин чадалтай хөрөнгө юм. Иймээс тухайн хөрөнгийн орлуулалтын өртөг буюу дахин үйлдвэрлэлийн өртгийг оновчтой сууриар тодорхойлох нь уг хөрөнгийн хувьд шаардлагатай үйлчилгээний чадавхийг тусгадаг.
47. Зарим тохиолдолд, аюулгүй байдлын буюу бусад шалтгааны улмаас нөөц буюу илүүдэл хүчин чадлыг хадгалдаг. Зохих үйлчилгээний чадавхи нь тухайн байгууллагын тодорхой нөхцөл байдалд бэлэн байгаа гэдгийг ханган магадлах хэрэгцээ шаардлагын улмаас ийм нөхцөл байдал үүсдэг. Жишээлбэл; галын алба нь гэнэтийн нөхцөл байдалд үйлчилгээ үзүүлэхийн тулд гал унтраах хэрэгслийг нөөцөд байлгах шаардлагатай байдаг. Ийм илүүдэл буюу нөөц хүчин чадал нь тухайн хөрөнгийн хувьд шаардлагатай үйлчилгээний чадавхийн нэг хэсэг юм.

*Нөхөн сэргээлтийн өртгийн хандлага*

48. Нөхөн сэргээлтийн өртөг гэдэг нь хөрөнгийн үйлчилгээний чадавхийг түүний үнэ цэнэ буурахын өмнөх түвшинд нөхөн сэргээн хадгалах өртөг зардал юм. Энэ хандлагын дагуу хөрөнгийн үлдсэн үйлчилгээний чадавхийг түүний үнэ цэнэ буурахын өмнөх түвшинд орлуулан бий болгох одоогийн өртөг зардлаас тэрхүү хөрөнгийн тооцоолсон нөхөн сэргээлтийн өртгийг хассанаар уг хөрөнгийн үлдсэн үйлчилгээний чадавхийн өнөөгийн үнэ цэнийг тодорхойлдог. Хөрөнгийн үлдсэн үйлчилгээний чадавхийг түүний үнэ цэнэ буурахын өмнөх түвшинд орлуулан бий болгох одоогийн өртгийг ихэвчлэн тухайн хөрөнгийн элэгдэл тооцсон дахин үйлдвэрлэлийн өртөг ба орлуулалтын өртгийн аль багаар тодорхойлдог. Хөрөнгийн

## МӨНГӨ БИЙ БОЛГОДОГГҮЙ ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

орлуулалтын өртөг буюу дахин үйлдвэрлэлийн өртгийг тодорхойлох нэмэлт заавар удирдамжийг 45 ба 47-р параграфт тусгасан.

### *Үйлчилгээний нэгжийн хандлага*

49. Үнэ цэнэ буурсан төлөв байдалд тухайн хөрөнгөөс хүлээгдэж буй үйлчилгээний нэгжийн буурсан тоо хэмжээтэй нийцүүлэн тохируулахын тулд тэрхүү хөрөнгийн үнэ цэнийн бууралтын өмнөх, үлдсэн үйлчилгээний чадавхийн одоогийн өртгийг бууруулснаар энэхүү хандлагын дагуу, хөрөнгийн үлдсэн үйлчилгээний чадавхийн өнөөгийн үнэ цэнийг тодорхойлдог. Нөхөн сэргээлтийн өртгийн хандлагад дурдсантай адилаар, тухайн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын өмнөх, үлдсэн үйлчилгээний чадавхийг орлуулах одоогийн өртгийг тэрхүү хөрөнгийн үнэ цэнийн бууралтын өмнөх элэгдэл тооцсон, дахин үйлдвэрлэлийн өртөг ба орлуулалтын өртгийн аль багаар ихэвчлэн тодорхойлдог.

### **Хандлагуудын хэрэглээ**

50. Ашиглалтын үнэ цэнийг хэмжих хамгийн тохиромжтой хандлагын сонголт нь мэдээний бэлэн боломжтой байдал болон үнэ цэнийн бууралтын шинж төрлөөс хамаардаг:
- (а) Технологийн, хуулийн буюу засгийн газрын бодлогын орчин дахь урт хугацааны мэдэгдэхүйц өөрчлөлтүүдээр тодорхойлсон үнэ цэнийн бууралтыг элэгдэл тооцсон орлуулалтын өртгийн хандлага эсвэл үйлчилгээний нэгжийн хандлагын аль тохиромжтойг ашигласнаар ерөнхийдөө хэмжих боломжтой байдаг;
  - (б) Ашиглалтын хэмжээ буюу арга маягийн урт хугацааны мэдэгдэхүйц өөрчлөлтүүдээр тодорхойлсон, үүн дотроо эрэлтийн зогсолт буюу бараг зогсолтоор тодорхойлсон үнэ цэнийн бууралтыг элэгдэл тооцсон орлуулалтын өртгийн хандлага эсвэл үйлчилгээний нэгжийн хандлагын аль тохиромжтойг ашигласнаар ерөнхийдөө хэмжих боломжтой байдаг;
  - (в) Биет эвдрэл, гэмтлийн улмаас тодорхойлсон үнэ цэнийн бууралтыг нөхөн сэргээлтийн өртгийн хандлага эсвэл элэгдэл тооцсон орлуулалтын өртгийн хандлагын аль тохиромжтойг ашигласнаар ерөнхийдөө хэмжих боломжтой байдаг.

### **Үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөх ба хэмжих**

51. Хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөх ба хэмжих шаардлагуудыг 52-57-р параграфт заасан. Энэ Стандарт дахь үнэ цэнийн бууралтын гарз гэсэн хэллэг нь өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзыг илэрхийлнэ.
52. **Хөрөнгийн нөхөгдөх үйлчилгээний дүн нь түүний дансны үнээс бага байх зөвхөн тийм тохиолдолд тухайн хөрөнгийн дансны үнийг**

**түүний нөхөгдөх үйлчилгээний дүн хүртэл бууруулна. Ийм бууралт нь үнэ цэнийн бууралтын гарз юм.**

53. 26-р параграфт дурдсанчлан, үнэ цэнийн бууралтын боломжит гарзын шинж тэмдэг байгаа бол, зөвхөн тийм тохиолдолд байгууллага нь нөхөгдөх үйлчилгээний дүнгийн албан ёсны тооцоолол хийхийг энэхүү Стандартаар шаарддаг. Үнэ цэнийн бууралтын гарз үүссэн байж болох гол шинж тэмдгүүдийг 27-33-р параграфт тодорхойлсон.
54. **Хөрөнгийг өөр бусад Стандартын (жишээлбэл, УСНББОУС 17 ба УСНББОУС 31-д заасан дахин үнэлгээний загварын) дагуу дахин үнэлсэн дүнгээр бүртгэснээс бусад тохиолдолд үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдалд шууд хүлээн зөвшөөрнө. Дахин үнэлсэн хөрөнгийн аливаа үнэ цэнийн бууралтын гарзыг уг бусад Стандартын дагуу дахин үнэлгээний бууралт гэж үзнэ.**
- 54А. Дахин үнэлээгүй хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Харин дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз нь тухайн хөрөнгийн ангийн дахин үнэлгээний нэмэгдлийн дүнгээс хэтрэхгүй байх тэр хэмжээ хүртэл үнэ цэнийн бууралтын гарзыг уг дахин үнэлгээний нэмэгдэлд хүлээн зөвшөөрнө. Дахин үнэлсэн хөрөнгийн ийм үнэ цэнийн бууралтын гарз нь тухайн хөрөнгийн ангийн дахин үнэлгээний нэмэгдлийг бууруулна.
55. **Үнэ цэнийн бууралтын гарзын хувьд тооцоолсон дүн нь холбогдох хөрөнгийнхөө дансны үнээс илүү байх тохиолдолд байгууллага нь зөвхөн бусад УСНББОУС-аар шаардсан бол зөрүүг өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.**
56. Тооцоолсон үнэ цэнийн бууралтын гарз нь хөрөнгийн дансны үнээс илүү байх тохиолдолд тухайн хөрөнгийн дансны үнийг тэг хүртэл бууруулж, холбогдох дүнг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Бусад УСНББОУС-аар шаардсан зөвхөн тийм тохиолдолд өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Жишээлбэл; цэргийн зориулалтаар барьсан байгууламжийг цаашид ашиглахгүй болсон бөгөөд хуульд зааснаар тухайн байгууллага нь ашиглахгүй болсон ийм байгууламжийг буулган нураах шаардлагатай байх. Хэрэв УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-өөр шаардсан бол уг байгууллага нь буулган нураах зардлын хувьд нөөц байгуулах шаардлагатай байж болох юм.
57. **Үнэ цэнийн бууралтын гарзын хүлээн зөвшөөрөлтийн дараа, уг хөрөнгийн үлдэх өртгийг (хэрэв байгаа бол) хассан, түүний хянан засварласан дансны үнийг тухайн хөрөнгийн үлдсэн ашиглалтын хугацаанд системтэйгээр хуваарилахын тулд хөрөнгийн элэгдлийн (хорогдуулгын) зардлыг ирээдүйн тайлант үедэд тохируулна.**

## Үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах

58. Хөрөнгийн хувьд өмнөх тайлант үеүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах шаардлагуудыг 59-70-р параграфт заасан.
59. Хөрөнгийн хувьд өмнөх тайлант үеүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарз нь цаашид оршин байхаа больсон буюу буурсан байж болох ямар нэг шинж тэмдэг байгаа эсэхийг байгууллага нь тайлант үе бүрийн эцэст үнэлнэ. Хэрэв ийм ямар нэг шинж тэмдэг байвал байгууллага нь тухайн хөрөнгийн нөхөгдөх үйлчилгээний дүнг тооцоолно.
60. Хөрөнгийн хувьд өмнөх тайлант үеүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарз нь цаашид оршин байхаа больсон буюу буурсан байж болох ямар нэг шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлэхдээ, тухайн байгууллага хамгийн наад зах нь дараах шинж тэмдгүүдийг харгалзан үзнэ:

### Мэдээллийн гадаад эх сурвалж

- (а) Тухайн хөрөнгөөр үзүүлэх үйлчилгээний эрэлт буюу хэрэгцээ шаардлага дахин сэргэсэн.
- (б) Уг байгууллагад тааламжтай нөлөө үзүүлэх урт хугацааны мэдэгдэхүйц өөрчлөлтүүд нь тэрхүү байгууллагын үйл ажиллагаа явуулдаг технологийн, хуулийн буюу засгийн газрын бодлогын орчинд тухайн тайлант үеийн туршид гарч тохиолдсон эсвэл ойрын ирээдүйд гарч тохиолдохоор байх;

### Мэдээллийн дотоод эх сурвалж

- (в) Уг байгууллагад тааламжтай нөлөө үзүүлэх урт хугацааны мэдэгдэхүйц өөрчлөлтүүд нь түүний хөрөнгөө ашиглаж байгаа эсвэл ашиглахаар хүлээгдэж буй хэмжээ, арга маягт тухайн тайлант үеийн туршид гарч тохиолдсон эсвэл ойрын ирээдүйд гарахаар хүлээгдэж байх. Хөрөнгийн гүйцэтгэлийг сайжруулах буюу нэмэгдүүлэх, тэрхүү хөрөнгөнд хамааралтай үйл ажиллагаанд бүтцийн өөрчлөлт хийхийн тулд тухайн тайлант үеийн туршид гаргасан өртөг зардал нь ийм өөрчлөлтөнд хамаарна.
- (г) Хөрөнгийг барьж байгуулах ажил дуусахаас эсвэл ашиглахад бэлэн болгохоос өмнө зогсоосон уг барилгын ажлыг дахин эхлүүлэх шийдвэр.
- (д) Хөрөнгийн үйлчилгээний гүйцэтгэл, үр дүн нь хүлээгдэж байснаас мэдэгдэхүйц сайн байх эсвэл сайн болно гэдгийг илтгэсэн нотолгоо дотоод тайлагналаас бий болсон байх.
61. 60-р параграфт дурдсан, үнэ цэнийн бууралтын гарзын багасалтын шинж тэмдгүүд нь үндсэндээ 27-р параграфт дурдсан үнэ цэнийн бууралтын боломжит гарзын шинж тэмдгүүдийн толин тусгал юм.

62. 60-р параграф дахь жагсаалтанд бүгдийг багтаагаагүй болно. Хөрөнгийн нөхөгдөх үйлчилгээний дүнг дахин тооцоолохыг уг байгууллагаас бас шаардаж болох үнэ цэнэ бууралтын буцаалтын өөр бусад шинж тэмдгүүдийг тухайн байгууллага тодорхойлж болох юм. Тухайлбал; дараах зүйлсийн аль нэг нь үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах шинж тэмдэг байж болно:
- (а) Хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийн мэдэгдэхүйц өсөлт; эсвэл
  - (б) Тухайн хөрөнгөөр үзүүлэх үйлчилгээний эрэлт буюу хэрэгцээ шаардлагын урт хугацааны мэдэгдэхүйц өсөлт.
63. Үйл ажиллагааг ойрын ирээдүйд зогсоох буюу бүтцийн өөрчлөлт хийх баталгаа нь тэрхүү үйл ажиллагаанд хамаарах хөрөнгийн ашиглалтын хэмжээ буюу арга маягийн хувьд тухайн байгууллагад тааламжтай нөлөө үзүүлэх урт хугацааны мэдэгдэхүйц өөрчлөлтийг илэрхийлэх тохиолдолд энэ нь хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтын шинж тэмдэг байна. Ийм баталгаа нь үнэ цэнийн бууралтын буцаалтын шинж тэмдэг байх нөхцөл байдал нь үйл ажиллагааны хүлээгдэж буй зогсоолт буюу бүтцийн өөрчлөлтөөр тухайн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах боломж бүрдүүлэлтэй ихэвчлэн холбоотой байдаг. Жишээлбэл; улсын эмнэлгийн удирдаж хянадаг хэвтэн эмчлэх тасагт ашиглалт багатай байдаг рентген аппаратыг бүтцийн өөрчлөлтийн үр дүнд эмнэлгийн рентген зураг авалтын тасагт шилжүүлж, ингэснээр түүний ашиглалт мэдэгдэхүйц сайжирсан. Ийм тохиолдолд уг хэвтэн эмчлэх тасгийн үйл ажиллагааг зогсоох буюу бүтцийн өөрчлөлт хийх баталгаа нь тухайн хөрөнгийн хувьд өмнөх тайлант үеүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах шинж тэмдэг байж болох юм.
64. Хөрөнгийн хувьд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарз нь цаашид оршин байхаа больсон буюу буурсан байж болох шинж тэмдэг байгаа бол хэдийгээр уг хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын гарзыг буцаагаагүй боловч энэ нь (а) хөрөнгийн ашиглалтын үлдсэн хугацаа, (б) элэгдлийн (хорогдуулгын) арга, (в) хөрөнгийн үлдэх өртгийг дахин хянан үзэж, тухайн хөрөнгөнд хамаарах Стандартын дагуу тохируулах шаардлагатай гэдгийг илэрхийлж болох юм.
65. **Хамгийн сүүлд үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрснөөс хойш тухайн хөрөнгийн нөхөгдөх үйлчилгээний дүнг тодорхойлоход ашигласан тооцоололд өөрчлөлт орсон зөвхөн тийм тохиолдолд уг хөрөнгийн хувьд өмнөх тайлант үеүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаана. Ингэж буцаахдаа 68-р параграфт зааснаас бусад тохиолдолд тухайн хөрөнгийн дансны үнийг түүний нөхөгдөх үйлчилгээний дүн хүртэл өсгөнө. Ийм өсөлт нь үнэ цэнийн бууралтын гарзын буцаалт юм.**
66. Үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтын шинж тэмдэг байгаа зөвхөн тийм тохиолдолд байгууллага нь нөхөгдөх үйлчилгээний дүнгийн албан ёсны тооцоолол хийхийг энэ Стандартаар шаарддаг. Тухайн хөрөнгийн хувьд өмнөх тайлант үеүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын



гарз нь цаашид оршин байхаа больсон буюу буурсан гэдгийг илэрхийлэх гол шинж тэмдгүүдийг 60-р параграфт тодорхойлсон.

67. Үнэ цэнийн бууралтын гарзын буцаалт нь байгууллага тухайн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын гарзыг хамгийн сүүлд хүлээн зөвшөөрсөн өдрөөс хойш хөрөнгийн ашиглалт буюу борлуулалтын аль нэгээр түүний тооцоолсон нөхөгдөх үйлчилгээний дүнд гарсан өсөлтийг илэрхийлдэг. Байгууллага нь нөхөгдөх үйлчилгээний дүнгийн өсөлтийн шалтгаан болж буй уг тооцооллын өөрчлөлтийг тодорхойлохыг 77-р параграфтаар шаардсан байдаг. Тооцооллын өөрчлөлтийн жишээнд дараах зүйлс хамаарна:
- (а) Нөхөгдөх үйлчилгээний дүнгийн суурьт орсон өөрчлөлт (өөрөөр хэлбэл, нөхөгдөх үйлчилгээний дүн нь борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэд эсвэл ашиглалтын үнэ цэнэд үндэслэсэн эсэх);
  - (б) Хэрэв нөхөгдөх үйлчилгээний дүн нь ашиглалтын үнэ цэнэд үндэслэсэн бол уг ашиглалтын үнэ цэнийн бүрэлдэхүүн хэсгүүдийн тооцоололд орсон өөрчлөлт; эсвэл
  - (в) Хэрэв нөхөгдөх үйлчилгээний дүн нь борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэд үндэслэсэн бол уг борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн бүрэлдэхүүн хэсгүүдийн тооцоололд орсон өөрчлөлт.
68. Үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтанд хамаарах хөрөнгийн нэмэгдсэн дансны үнэ нь хэрэв тухайн хөрөнгийн хувьд өмнөх тайлант үеүдэд үнэ цэнийн бууралтын гарз хүлээн зөвшөөрөөгүй байсан бол тодорхойлогдох байсан дансны үнээс (элэгдэл буюу хорогдуулгыг хассан цэвэр дүнгээс) хэтрэх ёсгүй.
69. Тухайн хөрөнгийг бусад Стандартын (жишээлбэл, УСНББОУС 17 ба УСНББОУС 31-д заасан дахин үнэлгээний загварын) дагуу түүний дахин үнэлсэн дүнгээр тайлагнаснаас бусад тохиолдолд уг хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтыг ашиг, алдагдалд нэн даруй хүлээн зөвшөөрнө. Дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзын аливаа буцаалтыг тэрхүү бусад Стандартын дагуу дахин үнэлгээний нэмэгдэлтэй адилаар авч үзнэ.
- 69А Дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтыг дахин үнэлгээний нэмэгдэлд шууд хүлээн зөвшөөрөх ба тухайн хөрөнгийн ангид хамаарах дахин үнэлгээний нэмэгдлийг өсгөнө. Гэвч тухайн дахин үнэлсэн хөрөнгийн ангид хамаарах үнэ цэнийн бууралтын гарзыг өмнө нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн тэр хэмжээгээр уг үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтыг мөн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.
70. Үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтыг хүлээн зөвшөөрсний дараа, үлдэх өртгийг (хэрэв байгаа бол) нь хассан уг хөрөнгийн хянан засварласан дансны үнийг түүний үлдсэн ашиглалтын хугацаанд системчилсэн сууриар хуваарилахын тулд тухайн хөрөнгийн элэгдлийн (хорогдуулгын) зардлыг ирээдүйн тайлант үеүдэд тохируулна.

## Хөрөнгийг дахин ангилах

71. Хөрөнгийг мөнгө бий болгогч хөрөнгөөс мөнгө бий болгодоггүй хөрөнгө болгох, эсвэл мөнгө бий болгодоггүй хөрөнгөөс мөнгө бий болгогч хөрөнгө болгох дахин ангилал нь тохиромжтой гэсэн тодорхой нотолгоо байгаа зөвхөн тийм тохиолдолд дахин ангиллыг хийнэ. Дахин ангилал нь өөрөө үнэ цэнийн бууралтын сорил хийх эсвэл үнэ цэнийн бууралтын гарзын буцаахад заавал хүргэх албагүй юм. Харин үнэ цэнийн бууралтын сорил эсвэл үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтын шинж тэмдэг нь дахин ангиллын дараа, тухайн хөрөнгөнд хамаарах хамгийн наад захын жагсаан харуулсан шинж тэмдгүүдээс үүсдэг.
72. Улсын секторын байгууллагууд нь мөнгө бий болгодоггүй хөрөнгийг мөнгө бий болгогч хөрөнгө болгон дахин ангилах нь тохиромжтой гэж шийдвэрлэж болох нөхцөл байдлууд байдаг. Жишээлбэл; бохир ус зайлуулах байгууламжийг анх нийтийн аж ахуйн албаны бохир усыг үнэ төлбөргүй зайлуулах зорилгоор барьсан. Уг нийтийн аж ахуйн алба татан буугдсан бөгөөд тухайн байгууламжийг цаашид аж үйлдвэрийн болон арилжааны зорилгоор ашиглахын тулд сайжруулан хөгжүүлнэ. Ирээдүйд аж үйлдвэрийн бохир усыг арилжааны үнэ ханшаар зайлуулах зорилгоор уг байгууламжийг ашиглахаар төлөвлөж байна. Энэ шийдвэрээс харахад, улсын секторын байгууллага нь уг бохир ус зайлуулах байгууламжийг мөнгө бий болгогч хөрөнгө гэж дахин ангилахаар шийдвэрлэжээ.

## Тодруулга

- 72A. Байгууллага нь мөнгө бий болгодоггүй хөрөнгийг мөнгө бий болгогч хөрөнгөөс ялган зааглахын тулд өөрийн боловсруулсан шалгуураа тодруулна.
73. Байгууллага нь хөрөнгийн анги тус бүрийн хувьд дараах зүйлсийг тодруулна:
- (a) Тухайн тайлант үеийн туршид ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзын дүн ба тэдгээр үнэ цэнийн бууралтын гарзыг тусгасан санхүүгийн үр дүнгийн тайлангийн мөрийн зүйлс.
  - (б) Тухайн тайлант үеийн туршид ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтын дүн ба тэдгээр үнэ цэнийн бууралтын гарзыг буцаасан санхүүгийн үр дүнгийн тайлангийн мөрийн зүйлс.
  - (в) Тухайн тайлант үеийн туршид дахин үнэлгээний нэмэгдэлд шууд хүлээн зөвшөөрсөн, уг дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзын дүн.

- (г) Тухайн тайлант үеийн туршид дахин үнэлгээний нэмэгдэлд шууд хүлээн зөвшөөрсөн, уг дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтын дүн.

73А. [Хассан]

74. Хөрөнгийн анги гэдэг нь байгууллагын үйл ажиллагааны хувьд ижил төсөөтэй шинж төрөл ба ашиглалт бүхий хөрөнгүүдийн бүлэглэл юм.

75. 73-р параграфт шаардсан мэдээллийг тухайн хөрөнгийн ангийн хувьд тодруулах бусад мэдээллийн хамт толилуулж болно. Жишээлбэл; УСНББОУС 17-гоор шаардсанчлан, тайлант үеийн эхэн ба эцэс дэх үндсэн хөрөнгийн дансны үнийн тохируулгын тайланд энэхүү мэдээллийг тусган оруулж болох юм.

76. **УСНББОУС 18, Сегментийн Тайлагнал-ын дагуу сегментийн мэдээллийг тайлагнаж буй байгууллага нь өөрийн тайлагнасан сегмент тус бүрийн хувьд дараах зүйлсийг тодруулна:**

(а) Тухайн тайлант үеийн туршид ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзын дүн.

(б) Тухайн тайлант үеийн туршид ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтын дүн.

77. **Байгууллага нь тухайн тайлант үеийн туршид хүлээн зөвшөөрсөн буюу буцаасан материаллаг үнэ цэнийн бууралтын гарз тус бүрийн хувьд дараах зүйлсийг тодруулна:**

(а) Үнэ цэнэ бууралтын гарзын хүлээн зөвшөөрөлт эсвэл буцаалтанд хүргэсэн үйл явдлууд болон нөхцөл байдлууд;

(б) Хүлээн зөвшөөрсөн эсвэл буцаасан үнэ цэнэ бууралтын гарзын дүн;

(в) Хөрөнгийн шинж төрөл;

(г) Хэрэв байгууллага нь УСНББОУС 18-ын дагуу сегментийн мэдээллийг тайлагнадаг бол тухайн хөрөнгийн харъяалагдах сегмент;

(д) Хөрөнгийн нөхөгдөх үйлчилгээний дүн нь түүний борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ эсвэл ашиглалтын үнэ цэнэ эсэх;

(е) Хэрэв нөхөгдөх үйлчилгээний дүн нь борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ бол уг борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийг тодорхойлоход ашигласан суурь (бодит үнэ цэнийг идэвхитэй зах зээлийн үнийг харгалзан лавлагаа болгосноор тодорхойлсон эсэх гэх мэт); ба

(ж) Хэрэв нөхөгдөх үйлчилгээний дүн нь ашиглалтын үнэ цэнэ бол ашиглалтын үнэ цэнийг тодорхойлохдоо ашигласан хандлага.

78. 77-р параграфын дагуу мэдээллийг нь тодруулаагүй тухайн тайлант үеийн туршид хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзын нэгтгэн нийлүүлсэн дүн ба үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтын нэгтгэн нийлүүлсэн дүнгийн хувьд байгууллага нь дараах мэдээллийг тодруулна:
- (а) Үнэ цэнийн бууралтын гарзаар нөлөө үзүүлсэн хөрөнгийн гол ангиуд (болон үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтаар нөлөө үзүүлсэн хөрөнгийн гол ангиуд); ба
  - (б) Эдгээр үнэ цэнийн бууралтын гарз ба үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтыг хүлээн зөвшөөрөхөд хүргэсэн гол үйл явдлууд болон нөхцөл байдлууд.
79. Байгууллага нь тухайн тайлант үеийн туршид хөрөнгийн нөхөгдөх үйлчилгээний дүнг тодорхойлохын тулд ашигласан гол таамаглалуудаа тодруулахыг дэмжинэ.

### Шилжилтийн нөхцөл

80. [Хассан]
- 80А. 27-р параграфын нэмэлт өөрчлөлтийг түүний мөрдсөн өдрөөс эхлэн гүйцээх горимоор мөрдөнө.
81. [Хассан]
- 81А. 2016 оны 7 дугаар сард гаргасан *Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт* (УСНББОУС 21 ба УСНББОУС 26-гийн нэмэлт өөрчлөлтүүд)-аар 2, 54, 69, 73-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулж, 7, 11-р параграфуудыг хассан ба 54А, 69А параграфуудыг шинээр нэмсэн. Эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг тэдгээрийн мөрдөх өдрөөс эхлэн гүйцээх горимоор мөрдөнө.

### Хүчин төгөлдөр болох хугацаа

82. Байгууллага нь энэхүү Стандартыг 2006 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2006 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 82А. УСНББОУС 31-ийн үр дүнд 2, 7-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулж, 26А, 26Б, 39А параграфуудыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2011 оны 4 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Хэрэв байгууллага нь 2011 оны 4 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед УСНББОУС 31-ийг

мөрдсөн бол эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.

- 82Б. 2011 оны 10 дугаар сард гаргасан *УСНББОУС 2011-ийн Сайжруулалтууд*-аар 27-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2013 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2013 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 82В. 2015 оны 01 дүгээр сард гаргасан *УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-ийн үр дүнд 80, 81, 83-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед *УСНББОУС 33-ыг* мөрдсөн бол эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.
- 82Г. 2015 оны 01 дүгээр сард гаргасан *УСНББОУС 35, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан* ба *УСНББОУС 37, Хамтын Хэлэлцээр*-ийн үр дүнд 13-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь *УСНББОУС 35* ба *УСНББОУС 37-г* мөрдсөн үеэс уг нэмэлт өөрчлөлтийг дагаж мөрдөнө.
- 82Д. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 3, 4, 15-р параграфуудыг хасаж, 6, 20, 21-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 82Е. *Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт (УСНББОУС 21 ба УСНББОУС 26-гийн нэмэлт өөрчлөлтүүд)*-аар 2, 54, 69, 73-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулж, 7, 11-р параграфуудыг хассан ба 54А, 69А, 81А параграфуудыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.

- 82Ж. 2016 оны 7 дугаар сард гаргасан УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийн үр дүнд 43-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 39-ийг мөрдөнө.
- 82И. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийн үр дүнд 14-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 20А параграфыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.
83. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

## Дүгнэлтийн Үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 21-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

*Оршил*

ДҮ1. УСНББОУС3-ийн СТОУС-тай нийцүүлэх хөтөлбөр нь УСНББОУС3-ийн ажлын хөтөлбөрийн чухал элемент юм. УСНББОУС3-ийн бодлого нь улсын секторын байгууллагуудад тохиромжтой тохиолдолд НББОУС3-өөс гаргасан СТОУС-тай аккруэл суурьт УСНББОУС-ыг нийцүүлэх явдал юм.

ДҮ2. НББОУС3-өөс гаргасан СТОУС-уудын шаардлагуудыг улсын секторт мөрдөх боломжтой тохиолдолд аккруэл суурьт УСНББОУС нь тэдгээр Стандартуудад үндэслэнэ. Энэ Стандартын шаардлагуудыг дээрх бодлоготой нийцүүлэн боловсруулсан. Хөрөнгийн үнэ цэнэ буурсан шинэ тэмдэг байгаа бол аж ахуйн нэгж нь тухайн хөрөнгийн нөхөгдөх дүнг тодорхойлохыг НББОУС 36-гаар шаардсан байдаг. Хөрөнгийн нөхөгдөх дүнг түүний ашиглалтын үнэ цэнэ ба борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн аль өндрөөр тодорхойлдог. Энэ Стандартад үүнтэй адил тодорхойлолтыг оруулсан байдаг.

ДҮ3. Энэ Стандартыг бие даан мөнгө бий болгодоггүй хөрөнгүүдэд мөрддөг бол НББОУС 36-г мөнгө бий болгогч хөрөнгө болон мөнгө бий болгогч нэгжүүдэд мөрддөг. Ингэснээр энэхүү хоёр стандартын хооронд олон зөрүү үүсэхэд хүргэдэг. Гол ялгаатай талууд нь:

- (а) Мөнгө бий болгодоггүй хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг энэ Стандартын дагуу хэмжих арга нь мөнгө бий болгогч хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг НББОУС 36-гийн дагуу хэмжихдээ ашиглах аргаас өөр байдаг;
- (б) Энэ Стандарт нь дахин үнэлсэн дүнгээр бүртгэсэн үндсэн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын сорил хийхийг байгууллагуудаас шаарддаггүй; ба
- (в) Энэ Стандарт нь цаг хугацаа урсан өнгөрөлт буюу хэвийн ашиглалтын үр дүнд хүлээгдэж болох хэмжээнээс мэдэгдэхүйц ихээр зах зээлийн үнэ цэнэд гарсан бууралтыг үнэ цэнийн бууралтын хамгийн наад захын шинж тэмдэгт оруулдаггүй. Энэ шинэ тэмдгийг үнэ цэнийн бууралт оршин байж болох нэмэлт шинж тэмдэг байдлаар тусган оруулдаг.

НББОУС 36-гийн шаардлагуудаас ингэж гажих болсон УСНББОУС3-ийн шалтгаан үндэслэлийг дараах параграфуудад тайлбарласан.

ДҮ4. 2000 онд гаргасан Саналын Урилга (СУ), *Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт* нь тохиромжтой хэмжээгээр НББОУС 36-г мөрддөг улсын секторын байгууллагуудын хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тайлагнах хандлагыг санал болгосон. СУ-д өгсөн хариултуудыг харгалзан үзсэний дараа Саналын Төсөл (СТ) 23, *Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-ыг боловсруулж,

## МӨНГӨ БИЙ БОЛГОДОГГҮЙ ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

2003 онд гаргасан. СТ 23-д өгсөн хариултуудыг харгалзан үзсэний дараа энэ Стандартыг боловсруулсан.

### Мөнгө бий болгогч хөрөнгө

ДҮ5. НББОУС 36 нь ашиглалтын үнэ цэнийг (а) хөрөнгийн тасралтгүй ашиглалтаас, (б) түүний ашиглалтын хугацааны эцэс дэх данснаас хасалтаас олохоор хүлээгдэж буй ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ байдлаар тодорхойлохыг аж ахуйн нэгжээс шаарддаг. Мөнгө бий болгогч хөрөнгийн үйлчилгээний чадавхийг тэдгээрийн ирээдүйн мөнгөн гүйлгээ бий болгох чадвар боломжоор тусган илэрхийлдэг. УСНББОУС 26 нь НББОУС 36-д үндэслэдэг. Улсын секторын байгууллагуудын эзэмшиж буй мөнгө бий болгогч хөрөнгүүдэд УСНББОУС 26-гийн шаардлагуудыг мөрдөх боломжтой байдаг. Энэ Стандарт нь улсын секторын мөнгө бий болгогч хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралтыг тайлагнахдаа УСНББОУС 26-г мөрдөхийг байгууллагуудаас шаарддаг.

ДҮ5А. УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийг 2017 оны 01 дүгээр сард гаргасан. УСНББОУС 40 нь гүүдвиллийг хүлээн зөвшөөрөх ба хэмжих шаардлагуудыг агуулсан байдаг. УСНББОУС 40-ийг боловсруулахдаа, УСНББОУС3 нь гүүдвиллийн үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг харгалзан үзсэн. Гүүдвилл нь бусад хөрөнгүүдээс бие даасан байдлаар эдийн засгийн үр өгөөж бий болгодоггүй, иймээс хөрөнгүүдийн бүлгийн нэг хэсэг байдлаар түүний үнэ цэнийн бууралтыг үнэлнэ гэдгийг УСНББОУС3 онцлон тэмдэглэдэг. Эерэг мөнгөн орлогын гүйлгээ эсвэл цэвэр мөнгөн зарлагын гүйлгээний бууралт эсэхээс үл хамааран мөнгөн гүйлгээг зөвхөн лавлагаа болгосноор гүүдвиллийг хэмжиж болно. УСНББОУС 21 нь зөвхөн бие даасан хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралтыг авч үздэг бөгөөд тухайн хөрөнгийн үлдсэн үйлчилгээний чадавхийн өнөөгийн үнэ цэнийг харгалзсанаар үнэ цэнийн бууралтыг үнэлдэг гэдгийг УСНББОУС3 мөн тэмдэглэсэн байдаг. Иймээс УСНББОУС3 нь гүүдвиллийн үнэ цэнийн бууралтанд УСНББОУС 21-ийг мөрдөх нь тохиромжгүй гэж дүгнэсэн. Гүүдвиллийн хамаарах үйл ажиллагаа нь мөнгө бий болгогч үйл ажиллагаа эсэхээс үл хамааран үнэ цэнийн бууралтын зорилгоор гүүдвиллийг мөнгө бий болгогч хөрөнгө гэж үзвэл зохино гэж УСНББОУС3 дүгнэсэн. УСНББОУС3 нь үнэ цэнийн бууралтын зорилгоор гүүдвиллийг мөнгө бий болгогч хөрөнгө гэж үзэх нэмэлт заавар удирдамжийг УСНББОУС 21 ба УСНББОУС 26-д тусган оруулахыг зөвшөөрсөн.

### Мөнгө бий болгодоггүй хөрөнгө

ДҮ6. Мөнгө бий болгодоггүй хөрөнгүүдэд хэрэглэж болох ашиглалтын үнэ цэнийн ойлголт ухагдахууны үндэслэл болох зарчмуудыг авч үзэхдээ, УСНББОУС3 нь мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үлдсэн үйлчилгээний чадавхийн өнөөгийн үнэ цэнийг лавлагаа болгосноор уг хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг хэмжих хэрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Энэ нь НББОУС 36-д авч үзсэн хандлагыг давтан хэрэглэж байна.



### **Ашиглалтын үнэ цэнийг тодорхойлох**

- ДҮ7. Мөнгө бий болгодоггүй хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийн (үлдсэн үйлчилгээний чадавхийн өнөөгийн үнэ цэнийн) тодорхойлолтыг олон арга замаар хийж болох юм. НББОУС 36-г давтан хэрэглэх нэг хандлага нь хэрэв байгууллага өөрийн үйлчилгээ буюу бусад гарц бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулсан бол үүсгэх байсан мөнгөн орлогын гүйлгээг тооцоолж, дискаунтчлах явдал юм. Гэвч УСНББОУС3-ийн үзэл бодлоор бол тухайн үйлчилгээ буюу бусад гарц бүтээгдэхүүний нэгжийн үнэ цэнийг тогтоох зохих үнийг тодорхойлох ба тохиромжтой дискаунтын хувийг тооцоолохтой холбоотой нарийн төвөгтэй байдлын улмаас энэхүү хандлагыг практикт хэрэглэж чадах магадлал бага байдаг.
- ДҮ8. Бусад хандлагууд нь ашиглалтын үнэ цэнийн шууд бус тодорхойлолтыг тусган илэрхийлдэг. Энэ зорилгоор УСНББОУС3 нь зах зээлийн үнэ цэнийн хандлага, түүнчлэн элэгдэл тооцсон орлуулалтын өртгийг хэмжих хандлагуудыг харгалзан үздэг бөгөөд нөхөн сэргээлтийн өртөг, үйлчилгээний нэгжийн өртгийн ач холбогдлыг тусган оруулдаг.

### *Зах зээлийн үнэ цэнийн хандлага*

- ДҮ9. Хөрөнгийн идэвхитэй зах зээл оршин байгаа тохиолдолд мөнгө бий болгодоггүй хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг энэхүү хандлагын дагуу тухайн хөрөнгийн ажиглаж болох зах зээлийн үнэ цэнээр хэмжинэ. Хөрөнгийн хувьд идэвхитэй зах зээл байхгүй тохиолдолд тухайн давамгайлах нөхцөл байдалд зах зээлийн оролцогчдоор төлүүлэхээр бэлтгэхийн тулд тэрхүү хөрөнгийн хамгийн өндөр ба хамгийн сайн ашиглалтыг харгалзан үзсэнээр уг байгууллага нь зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хоорондох хамааралгүй ажил гүйлгээгээр хөрөнгийг арилжиж болох үнийн талаархи зах зээлийн боломжит хамгийн сайн нотолгоог ашиглана. Зах зээлийн үнэ цэнэ нь хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээс (нөхөгдөх үйлчилгээний дүнгийн тооцооллын нөгөө тал) зөвхөн данснаас хасалтын зардлын дүнгээр ялгаатай байдаг тул ашиглалтын үнэ цэнийн төлөөлөл болгон уг ажиглаж болох зах зээлийн үнэ цэнийг ашиглах нь илүүдэл ажил гэдгийг УСНББОУС3 тэмдэглэсэн. Иймээс нөхөгдөх үйлчилгээний дүнгийн нөгөө тал болох, борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээр уг зах зээлийн үнэ цэнийг үр дүнтэйгээр тооцоолж болно.

### *Элэгдэл тооцсон орлуулалтын өртгийн хандлага*

- ДҮ10. Энэхүү хандлагын дагуу хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг хамгийн бага өртөөг тодорхойлдог. Энэ нь хэвийн үйл ажиллагааны явцад олж авч болох тухайн хөрөнгөнд агуулагдаж буй нийт үйлчилгээний чадавхиас нэгэнт ашиглан зарцуулсан үйлчилгээний чадавхийн үнэ цэнийг хассан дүн байна. Энэ хандлага нь хэрэв хөрөнгийг данснаас хассан тухайн хөрөнгийн үлдсэн үйлчилгээний чадавхийг уг байгууллага сольж орлуулна гэж үздэг. Хөрөнгийг дахин үйлдвэрлэл (тусгай хөрөнгө гэх мэт) эсвэл түүний нийт үйлчилгээний чадавхийн орлуулалтаар сольж орлуулж болох

## МӨНГӨ БИЙ БОЛГОДОГГҮЙ ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

юм. Иймээс ашиглалтын үнэ цэнийг тухайн хөрөнгийн дахин үйлдвэрлэлийн өртөг эсвэл орлуулалтын өртгийн аль багаар хэмжих бөгөөд тэрхүү хөрөнгийн нэгэнт ашиглан зарцуулсан буюу хугацаа дууссан үйлчилгээний чадавхийг тусгахын тулд уг өртөгт үндэслэн тооцоолсон, хуримтлагдсан элэгдлийг өртгөөс хасдаг.

### *Нөхөн сэргээлтийн өртгийн хандлага*

ДҮ11. Үнэ цэнийн бууралтын гарз нь эвдрэл, гэмтлээс үүссэн тохиолдолд энэ хандлагыг ихэвчлэн хэрэглэдэг. Энэхүү хандлагын дагуу хөрөнгийн үнэ цэнэ буурахын өмнөх элэгдэл тооцсон орлуулалтын өртөг буюу нөхөн сэргээлтийн өртгөөс уг хөрөнгийн тооцоолсон нөхөн сэргээлтийн өртгийг хассанаар түүний ашиглалтын үнэ цэнийг тодорхойлдог.

### *Үйлчилгээний нэгжийн хандлага*

ДҮ12. Энэ хандлага нь үнэ цэнэ буурсан төлөв байдалд тухайн хөрөнгөөс хүлээгдэж буй үйлчилгээний нэгжийн буурсан тоо хэмжээтэй нийцүүлэн тохируулахын тулд тэрхүү хөрөнгийн үнэ цэнийн бууралтын өмнөх, элэгдэл тооцсон орлуулалтын өртөг буюу дахин үйлдвэрлэлийн өртгийг бууруулснаар уг хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг тодорхойлдог.

### *Хэрэглэх хандлагууд*

ДҮ13. УСНББОУСЗ нь дээр дурдсан, элэгдэл тооцсон орлуулалтын өртөг, нөхөн сэргээлтийн өртөг, үйлчилгээний нэгжийн хандлагуудын аль тохиромжтойг ашигласнаар уг мөнгө бий болгодоггүй хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг хэмжихийг зөвшөөрдөг.

### **Бусад хөрөнгүүд**

ДҮ14. УСНББОУС 21 нь биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг сорьж шалгах, биет бус хөрөнгөтэй холбоотой үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөх ба хэмжих тусгай шаардлагуудыг агуулсан байдаг. Эдгээр шаардлагууд нь УСНББОУС 31, *Биет Бус Хөрөнгө*-ийн шаардлагуудын нэмэлт гүйцээлт юм. Өртгөөр нь хэмжсэн, мөнгө бий болгодоггүй биет бус хөрөнгүүдийг энэ Стандартын цар хүрээнд хамруулах бөгөөд энэ Стандартын шаардлагуудын дагуу үнэ цэнийн бууралтыг сорьж шалгах хэрэгтэй.

### **Хөрөнгүүдийн бүлэг ба корпорацийн хөрөнгө**

ДҮ15. НББОУС 36-д зааснаар, бие даасан хөрөнгийн нөхөгдөх дүнг тодорхойлох боломжгүй тохиолдолд тухайн хөрөнгийн мөнгө бий болгогч нэгжийн (МББН) нөхөгдөх дүнг тодорхойлдог. МББН гэдэг нь (а) тасралтгүй ашиглалтаас мөнгөн орлогын гүйлгээ бий болгодог, (б) бусад хөрөнгүүд буюу хөрөнгүүдийн бүлгийн мөнгөн орлогоос бүрэн хамааралгүй байдлаар мөнгөн орлогыг бий болгодог хөрөнгүүдийн тодорхойлж болох хамгийн бага бүлэг юм. УСНББОУСЗ нь мөнгө бий болгодоггүй хөрөнгийн хүрээнд үйлчилгээ бий болгогч нэгж гэсэн ойлголт ухагдахууныг авч үзсэн.

Бие даасан хөрөнгүүдийн үйлчилгээний чадавхийг тодорхойлох боломжтой учраас энэ Стандартын шаардлагуудыг бие даасан хөрөнгүүдэд мөрдөхдөө, энэхүү ойлголт ухагдахууныг НББОУС 36 дахь МББН-ийн ухагдахуунтай адилаар хэрэглэх шаардлагагүй гэдгийг УСНББОУСЗ онцлон тэмдэглэсэн. Түүнчлэн, ингэж хэрэглэх нь мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үнэ цэнийн бууралтын тайлагналд хэт төвөгтэй байдлыг үүсгэх юм.

ДҮ16. Хоёр буюу хэд хэдэн МББН-ийн ирээдүйн мөнгөн гүйлгээнд хувь нэмрээ оруулдаг гүүдвэллээс бусад хөрөнгийг НББОУС 36-гийн дагуу корпорацийн хөрөнгө гэж нэрлэдэг. Мөнгө бий болгогч хөрөнгийн хүрээнд авч үзвэл, корпорацийн хөрөнгө нь дангаараа мөнгөн орлогын гүйлгээ бий болгодоггүй учраас уг корпорацийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг түүний харъяалагдах мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтын нэг хэсэг байдлаар авч үздэг. Дээрх ДҮ15-д тэмдэглэсэнчлэн, мөнгө бий болгодоггүй хөрөнгийн хүрээнд, үйлчилгээ бий болгогч нэгж гэсэн ойлголт ухагдахуун нь баталгаатай бус болохыг УСНББОУСЗ ажиглан тэмдэглэсэн. Түүнчлэн, ийм хөрөнгө нь үйлчилгээ үзүүлэх чиг үүргийн салшгүй нэг хэсэг ямагт байдаг бөгөөд тэдгээрийн үнэ цэнийн бууралтыг тухайн байгууллагын мөнгө бий болгодоггүй аливаа бусад хөрөнгүүдтэй адилтган авч үзнэ гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн.

#### **Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгө**

ДҮ17. Энэ Стандартыг 2004 оны 12 дугаар сард батлан гаргах үед энэ нь УСНББОУС 17 ба УСНББОУС 31-д заасан, дахин үнэлгээний загварын дагуу дахин үнэлсэн дүнгээр бүртгэсэн, мөнгө бий болгодоггүй хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын сорил хийхийг шаарддаггүй байсан. УСНББОУСЗ-ийн үзэл бодлоор бол, УСНББОУС 17 ба УСНББОУС 31-д заасан дахин үнэлгээний загварын дагуу, хөрөнгийг тухайн тайлангийн өдрөөрх түүний бодит үнэ цэнээс материаллаг зөрүүгүй байх тийм дүнгээр бүртгэсэн гэдгийг ханган магадлахын тулд хөрөнгийг хангалттай тогтмол дахин үнэлдэг бөгөөд аливаа үнэ цэнийн бууралтыг тэрхүү үнэлгээнд харгалзан тусгадаг. Иймээс хөрөнгийн дансны үнэ ба түүний борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн хоорондох аливаа зөрүү нь данснаас хасалтын зардал байх юм. УСНББОУСЗ-ийн үзэл бодлоор бол энэ нь ихэнх тохиолдолд материаллаг бус байх бөгөөд практик үүднээс авч үзвэл, тухайн хөрөнгийн нөхөгдөх үйлчилгээний дүнг хэмжих ба мөнгө бий болгодоггүй хөрөнгийн данснаас хасалтын зардлын хувьд үнэ цэнийн бууралтын гарз хүлээн зөвшөөрөх шаардлагагүй байдаг.

ДҮ18. Энэ Стандартаас ялгаатай нь, НББОУС 36 нь дахин үнэлсний дараа уг дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг сорьж шалгахыг аж ахуйн нэгжүүдээс шаарддаг. Ийм ялгаатай байдлын учир шалтгааныг доорх ДҮ19 ба ДҮ20 параграфуудад дурдсан хүчин зүйлсийг харгалзсанаар тайлбарладаг.

ДҮ19. Нэгдүгээрт, энэ Стандартын дагуу нөхөгдөх үйлчилгээний дүнг тодорхойлох ба НББОУС 36-гийн дагуу нөхөгдөх дүнг тодорхойлох янз

бүрийн аргууд байдаг. Энэ Стандартад нөхөгдөх үйлчилгээний дүнг мөнгө бий болгодоггүй хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ ба ашиглалтын үнэ цэнийн аль өндөр нь гэж тодорхойлдог. Мөн энэ Стандартын дагуу, байгууллага нь тухайн хөрөнгийн үлдсэн үйлчилгээний чадавхийг орлуулан бий болгох одоогийн өртгийг тогтоосноор тэрхүү хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг тодорхойлдог. Хөрөнгийн үлдсэн үйлчилгээний чадавхийг орлуулан бий болгох одоогийн өртгийг элэгдэл тооцсон орлуулалтын өртгийн хандлага, түүнчлэн нөхөн сэргээлтийн өртгийн хандлага ба үйлчилгээний нэгжийн хандлага гэж тодорхойлсон хандлагуудыг ашигласнаар тодорхойлдог. УСНББОУС 17 ба УСНББОУС 31-гийн дагуу бодит үнэ цэнийг хэмжихийн тулд мөн эдгээр хандлагуудыг ашиглаж болох бөгөөд ингэснээр ашиглалтын үнэ цэнэ нь бодит үнэ цэнийн хэмжүүр болох юм. Нөхөгдөх дүнг НББОУС 36-д хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ ба түүний ашиглалтын үнэ цэнийн аль өндөр нь гэж тодорхойлсон байдаг. НББОУС 36-гийн дагуу, хөрөнгийн тасралтгүй ашиглалтаас болон түүний эцсийн данснаас хасалтаас олохоор хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийг ашиглан тухайн хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг тодорхойлдог. Уг ашиглалтын үнэ цэнэ нь тухайн хөрөнгийн бодит үнэ цэнээс өөр байж болно гэдгийг НББОУС 36-д тэмдэглэсэн байдаг.

ДҮ20. Хоёрдугаарт, мөнгө бий болгогч нэгж үүсгэхийн тулд мөнгө бий болгодоггүй хөрөнгүүдийг мөнгө бий болгогч хөрөнгүүдтэй нэгтгэн нийлүүлэх талаархи НББОУС 36-гийн шаардлагыг энэ Стандартад тусган оруулаагүй. НББОУС 36-гийн дагуу хөрөнгө нь мөнгөн орлогын гүйлгээ үүсгэдэггүй тохиолдолд мөнгө бий болгогч нэгж үүсгэхийн тулд түүнийг бусад хөрөнгүүдтэй нэгтгэн нийлүүлж, үүний дараа тэрхүү хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг хэмждэг. Мөнгө бий болгогч нэгжийг бүрдүүлж буй хөрөнгүүдийн бодит үнэ цэнийн нийлбэр нь уг мөнгө бий болгогч нэгжийн ашиглалтын үнэ цэнээс өөр байж болох юм.

***Дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (УСНББОУС 21 ба УСНББОУС 26-гийн нэмэлт өөрчлөлтүүд)***

ДҮ20А. УСНББОУС-уудыг мөрдөж буй улс орнуудаас гаргасан хүсэлтийн үр дүнд 2015 онд УСНББОУС3 нь дахин үнэлсэн үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийг УСНББОУС 21-ийн цар хүрээнээс хасах тухай өөрийн анхны шийдвэрийг эргэн харсан.

ДҮ20Б. УСНББОУС 21 ба НББОУС 36-ийн ялгаатай шаардлагуудын талаархи дээрх ДҮ19 болон ДҮ20 параграфууд дахь шалтгаан үндэслэл хүчин төгөлдөр хэвээр байна гэж УСНББОУС3 үзсэн. УСНББОУС 17-гийн 44-р параграф ба УСНББОУС 31-ийн 74-р параграфар шаардсанчлан, хөрөнгийн дансны үнэ нь түүний бодит үнэ цэнээс материаллаг зөрүүгүй гэдгийг ханган магадлахын тулд хөрөнгийн дахин үнэлгээг хийдэг тохиолдолд үнэ цэнийн бууралтыг харгалзан үзнэ гэсэн байр суурьтай байгаагаа УСНББОУС3 мэдэгдсэн.

ДҮ20В. Үнэ цэнийн бууралтын гарз ба үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтыг дахин үнэлгээтэй төсөөтэй байдлаар тайлагнадаг гэдэгт үндэслэн тэдгээр нь дахин үнэлгээ эсэх хоёрдмол утга үүсэж байгааг УСНББОУСЗ мөн онцлон тэмдэглэсэн. Хэрэв үндсэн хөрөнгийн тодорхой нэг ангид харъяалагдах үндсэн хөрөнгийн зүйлийг дахин үнэлсэн бол тэдгээр хөрөнгүүдийн нийт ангийг дахин үнэлэхийг УСНББОУС 17-гийн 51-р параграфтаар шаардсан байдаг. Иймээс үнэ цэнийн бууралтын гарз ба үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтыг дахин үнэлгээ гэж тайлбарлавал үр дагавар нь алдаатай болох юм. УСНББОУСЗ нь үүнийг хоёрдмол утгатай байдлаар шийдвэрлэвэл зохино гэж үзсэн.

ДҮ20Г. УСНББОУСЗ нь УСНББОУС 21-ийн 77 ба 78-р параграфуудад тусгайлан заасан үнэ цэнийн бууралтын тоон болон чанарын шинжтэй мэдээллээр хэрэглэгчдийг хангах нь чухал ач холбогдолтой гэж бас үзсэн.

ДҮ20Д. Дээрх хоёрдмол утгыг тодруулах УСНББОУСЗ-ийн зорилго бол дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз ба үнэ цэнийн бууралтын гарзын буцаалт нь уг дахин үнэлсэн зүйлийн хувьд үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөхийн тулд тэрхүү зүйлийн харъяалагдах хөрөнгийн нийт ангийг дахин үнэлэхийг тухайн байгууллагаас шаардахгүй гэдгийг ханган магадлах явдал юм.

ДҮ20Е. Дахин үнэлсэн дүнгээр хэмждэг үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийг УСНББОУС 21-ийн цар хүрээнд хамруулан оруулах нь тухайн хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болох аливаа шинж тэмдэг байгаа эсэхийг уг байгууллага жил бүр үнэлэх шаардлагатай гэдгийг илэрхийлэх боловч тэрхүү байгууллага нь үнэ цэнийн бууралтын аливаа шинж тэмдгүүдийг мэдэх магадлалтай байдаг. Иймээс дахин үнэлсэн дүнгээр хэмждэг үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийг УСНББОУС 21-ийн цар хүрээнд хамруулан оруулах нь санхүүгийн тайлан бэлтгэгчийн хувьд ноцтой алдаа болохгүй гэж УСНББОУСЗ дүгнэсэн.

ДҮ20Ж. Эдгээр анхаарах зүйлсийн улмаас УСНББОУСЗ нь СТ 57, *Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-ыг 2015 оны 9 дүгээр сард батлан гаргасан бөгөөд энэхүү СТ-г дараа сард нь хэвлэн нийтэлсэн.

### **СТ 57-д өгсөн хариултууд**

ДҮ20И. СТ57-д хариу өгсөн ихэнх хүмүүс нь уг санал болон УСНББОУСЗ-ийн шалтгаан үндэслэлийг дэмжсэн. Дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз ба үнэ цэнийн бууралтын гарзын буцаалт нь тэрхүү зүйлийн харъяалагдах хөрөнгийн нийт ангийг дахин үнэлэхийг тухайн байгууллагаас шаардахгүй гэсэн тодруулгад УСНББОУС 17 дахь энгийн мэдэгдлээр илүү хялбархан хүрч болно гэсэн саналыг УСНББОУСЗ авч үзсэн.

ДҮ20К. УСНББОУСЗ нь ийм үзэл бодлыг мэдэгдсэн боловч хоёр шалтгааны улмаас түүнийг тохиромжгүй гэж үзсэн. Нэгдүгээрт, хөрөнгийн нөхөгдөх үйлчилгээний дүнг үнэлэх үед ийм хандлага нь мөнгө бий болгодоггүй

## МӨНГӨ БИЙ БОЛГОДОГҮЙ ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

хөрөнгүүдийн ашиглалтын үнэ цэнийг тодорхойлох янз бүрийн аргуудыг хангалттай харгалзан үздэггүй. Ийм аргууд нь элэгдэл тооцсон орлуулалтын өртгийн хандлага, нөхөн сэргээлтийн өртгийн хандлага, үйлчилгээний нэгжийн хандлага юм. Хоёрдугаарт, уг хандлага нь УСНББОУС 21 ба УСНББОУС 26-д тодруулгын заалт оруулснаар хэрэглэгчдийн тайлагналын хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгод шаардлагатай мэдээллээр хангахгүй юм. Иймээс УСНББОУС3 нь СТ 57 дахь өөрийн саналуудаа эцсийн тунхаглалд хүчин төгөлдөр болгон оруулахаар шийдвэрлэсэн.

ДҮ20Л. СТ-д өгсөн хариултуудыг харгалзан үзсэний дараа, УСНББОУС3 нь үнэ цэнийн бууралт бол дахин үнэлгээний бууралтаас онолын хувьд ялгаатай гэсэн СТ 57-гийн Дүгнэлтийн Үндэслэлийн батламж мэдэгдлийг дахин хянан үнэлсэн. Үнэ цэнийн бууралт ба дахин үнэлгээний бууралтын аль аль нь үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөж бий болгох чадвар боломжийн бууралтыг агуулдаг учраас эдгээр нь онолын хувьд ижил гэж УСНББОУС3 дүгнэсэн. Гэвч практикт ялгаатай талууд байдаг. Үнэ цэнийн бууралт нь үечилсэн дахин үнэлгээний үр дүнд биш, харин бие даасан хөрөнгө буюу хөрөнгүүдийн бүлэгт нөлөө үзүүлдэг үйл явдал юм. “УСНББОУС 21 ба УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-ын дагуу тооцох үнэ цэнийн бууралтын гарз болон үнэ цэнийн бууралтын гарзын буцаалт нь тэрхүү хөрөнгө буюу хөрөнгүүдийн бүлгийн харъяалагдах хөрөнгийн ангийг дахин үнэлэх хэрэгцээ шаардлагыг заавал үүсгэн бий болгохгүй” гэсэн мэдэгдлийг УСНББОУС 17-гийн 51А параграфт оруулснаар энэхүү практикын ялгаатай байдлыг тусгасан.

### **УҮГ-ын эзэмшиж буй мөнгө бий болгодоггүй хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралт**

ДҮ21. Энэ Стандартыг анх гаргах үед энэ Стандарт нь [УҮГ-ын] эзэмшиж буй бүх хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг НББОУС 36-гийн дагуу тайлагнахыг шаарддаг байсан (2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргаснаас хойш дээрх дөрвөлжин хаалтанд тусгасан нэр томъёог ашиглахаа больсон). Энэ Стандартыг гаргах үед УҮГ нь ашгийн төлөө байгууллага байсан бөгөөд түүний ашиглаж буй хөрөнгүүд нь үндсэндээ мөнгө бий болгогч хөрөнгүүд байсан. Энэ Стандартыг гаргасны дараа *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* нь УҮГ бол ашгийн төлөө байгууллага, иймээс СТОУС ба НББОУС-ыг дагаж мөрдөх шаардлагатай гэдгийг тодорхой болгож өгсөн. Энэ Стандартыг гаргасны дараа бие даасан УСНББОУС-ууд нь УҮГ-т СТОУС-ыг мөрдөнө гэдгийг тодорхой ойлгомжтой болгосон. Иймээс НББОУС 36-гийн дагуу үнэ цэнийн бууралтыг нь сорьж шалгах мөнгө бий болгогч нэгжийг бүрдүүлэхийн тулд мөнгө бий болгодоггүй хөрөнгүүдийг УҮГ-тай зохих ёсоор нэгтгэн бүлэглэнэ гэж үзэх болсон.

**Үнэ цэнийн бууралтын шинж тэмдгүүд – Зах зээлийн үнэ цэнийн өөрчлөлтүүд**

ДҮ22. Хөрөнгийн зах зээлийн үнэ цэнэ нь цаг хугацаа урсан өнгөрөлт буюу тухайн хөрөнгийн хэвийн ашиглалтын үр дүн байдлаар хүлээгдэж байснаас мэдэгдэхүйц их дүнгээр буурсан гэдгийг харуулах үнэ цэнийн бууралтын хамгийн наад захын шинж тэмдгүүдийг НББОУС 36-д тусгасан байдаг. УСНББОУСЗ нь үүнийг үнэ цэнийн бууралтын хамгийн наад захын шинж тэмдэг биш, харин үнэ цэнийн бууралтын нэмэлт шинж тэмдэг байдлаар тусган оруулсан. УСНББОУСЗ-ийн үзэл бодлоор бол зах зээлийн үнэ цэнийн ийм өөрчлөлт нь мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үнэ цэнэ буурсан гэдгийг заавал илэрхийлэх албагүй юм. Яагаад гэвэл, мөнгө бий болгодоггүй хөрөнгүүдийг арилжааны өгөөж бий болгохоос өөр бусад шалтгаанаар эзэмшдэг. Иймээс зах зээлийн үнэ цэнийн өөрчлөлт нь тухайн хөрөнгийн тасралтгүй ашиглалтаас уг байгууллагын нөхөх үйлчилгээний дүнгийн өөрчлөлтийг тусгаагүй байж болох юм.

**Үнэ цэнийн бууралтын буцаалт**

ДҮ23. Тухайн хөрөнгөөр үзүүлэх үйлчилгээний эрэлт буюу хэрэгцээ шаардлага дахин сэргэлтийг 60(а) параграфт үнэ цэнийн бууралтын буцаалтын хамгийн наад захын шинж тэмдэг байдлаар тусган оруулсан. Харин тухайн хөрөнгөөр үзүүлэх үйлчилгээний эрэлт буюу хэрэгцээ шаардлагын урт хугацааны мэдэгдэхүйц өсөлтийг 62(б) параграфт үнэ цэнийн бууралтын боломжит буцаалтын нэмэлт шинж тэмдэг байдлаар тусган оруулсан. Эдгээр хоёр шинж тэмдгийн хэллэг төсөөтэй байна; гэвч 60(а) параграф нь буурсан ба үнэ цэнийн бууралтын гарз хүлээн зөвшөөрөхөд хүргэсэн эрэлтийн бууралтын дахин сэргэлтийг илэрхийлж байгаа учраас тэдгээрийг өөр хооронд нь ялгаатай авч үзэж болох юм. Харин 62(б) параграф нь шинэ эрэлтийг илэрхийлэх бөгөөд тухайн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын гарз хүлээн зөвшөөрсөн учир шалтгаантай холбоогүй байж болох юм.

ДҮ24. Хөрөнгийн үнэ цэнийн мэдэгдэхүйц өсөлтийг 62(б) параграф нь үнэ цэнийн бууралтын буцаалтын нэмэлт шинж тэмдэг байдлаар тусгадаг. Энэ нь зах зээлийн үнэ цэнийн бууралт бол цаг хугацаа урсан өнгөрөлт буюу хэвийн ашиглалтын үр дүнд хүлээгдэж болох хэмжээнээс мэдэгдэхүйц ихээр буурсан байхыг шаарддаг 29(а) параграфт дурдсан, үнэ цэнийн бууралтын шинж тэмдгийн толин тусгал биш юм. Ийм ялгаатай байдал нь зах зээлийн үнэ цэнийн өсөлт хүлээгдсэн эсвэл хүлээгдээгүй байж болно гэдгийг иэрхийлдэг.

ДҮ25. “Биет эвдрэл, гэмтлийн талаархи нотолгоо байх”-ыг 27(в) параграфт үнэ цэнийн бууралтын хамгийн наад захын шинж тэмдэг байдлаар тусган оруулсан. Энэхүү үнэ цэнийн бууралтын шинж тэмдгийн толин тусгал болох үнэ цэнийн бууралтын буцаалтын шинж тэмдгийг 60-р параграфт тусган оруулаагүй. Дараагийн тайлант үеийн зарлага нь хөрөнгийн гүйцэтгэлийн хамгийн сүүлд үнэлсэн стандартаас илүү давж гарсан, ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг уг

хөрөнгийн нийт ашиглалтын хугацаанд тухайн байгууллагад бий болгох нилээд их магадлалтай тохиолдолд тэрхүү дараагийн тайлант үеийн зарлагыг хөрөнгийн дансны үнэ дээр нэмэхийг УСНББОУС 17 нь байгууллагуудаас шаарддаг тул УСНББОУСЗ нь хөрөнгийн засварыг үнэ цэнийн бууралтын буцаалтын шинж тэмдэг гэж үздэггүй. УСНББОУС 16-д заасан өртгийн загварыг ашиглан хэмждэг, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хувьд энэ шаардлагыг бас мөрдөнө. Эдгээр шаардлагууд нь үнэ цэнийн бууралтын биет эвдрэл, гэмтлийн шинж тэмдгийн толин тусгал болох үнэ цэнийн бууралтын буцаалтын шинж тэмдгийн хэрэгцээ шаардлагыг үгүйсгэнэ гэж УСНББОУСЗ үздэг. Биет эвдрэл, гэмтлийн нөхөн сэргээлт буюу засвар нь энэ Стандартын 65-р параграфт тусгайлан заасан үнэ цэнийн бууралтын дараах, тухайн хөрөнгийн нөхөгдөх үйлчилгээний дүнгийн тооцооллын өөрчлөлтийг орлохгүй гэдгийг УСНББОУСЗ мөн онцлон тэмдэглэсэн.

**2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУСЗ-ийн *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ын үр дүнд УСНББОУС 21-д хийсэн хянан засварлалт**

ДҮ26. УСНББОУСЗ нь 2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (а) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р параграфт* нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.



## Хэрэгжүүлэх заавар удирдамж

*Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 21-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### Үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг (27-р параграф)

*Мэдээллийн гадаад эх сурвалж*

**(а) Тухайн хөрөнгөөр үзүүлэх үйлчилгээний эрэлт буюу хэрэгцээ шаардлага нь зогссон буюу бараг зогссон.**

ХЗУ1. Хөрөнгө нь үйлчилгээний чадавхиа хэвээр хадгалсаар байгаа боловч тэрхүү үйлчилгээний эрэлт нь зогссон буюу бараг зогссон. Ийм маягаар үнэ цэнэ буурсан хөрөнгийн жишээнд дараах зүйлс хамаарна:

- (а) Хүн ам нь өөр бус нутагт нүүн шилжснээр сургуулийн эрэлт хэрэгцээ багассаны улмаас сургууль хаагдсан. Сургуулийн эрэлт хэрэгцээнд нөлөөлөх хүн ам зүйн энэхүү хандлага нь ойрын ирээдүйд өөрчлөгдөх төлөвгүй байна;
- (б) 1,500 оюутанд зориулагдсан сургууль нь одоогоор 150 оюутантай байна. Хамгийн ойрхоны өөр сургууль нь 100 километрийн зайтай учраас уг сургуулийг хааж болохгүй. Байгууллага нь оюутнуудын тоо нэмэгдэнэ гэж бодохгүй байна. Анх сургуулийг байгуулах үед 1,400 оюутантай байсан. Хэрэв ирээдүйд оюутнуудын тоо 150 болно гэдгийг мэдсэн бол уг байгууллага нь арай бага хүчин чадалтай сургууль байгуулах байсан. Байгууллага нь эрэлт бараг зогссон гэж тодорхойлсон бөгөөд уг сургуулийн нөхөгдөх үйлчилгээний дүнг түүний дансны үнэтэй зэрэгцүүлэх хэрэгтэй;
- (в) Төмөр замын шугам нь санхүүгийн дэмжлэг дутагдалтайн улмаас хаагдсан (тухайлбал; сүүлийн дараалсан хэдэн жилүүдийн ган гачгийн улмаас хөдөөгийн хүн амын ихэнх хэсэг нь хот руу нүүсэн бөгөөд тэнд үлдсэн хүмүүс нь илүү хямд автобусны үйлчилгээг ашиглах болсон);
- (г) Үндсэн хөлслөн ашиглагч нар нь хөлслөх гэрээгээ шинэчлэн байгуулаагүйн улмаас цэнгэлдэх хүрээлэн нь хаагдахаар болоод байна.

**(б) Уг байгууллагад сөрөг нөлөөтэй урт хугацааны мэдэгдэхүйц өөрчлөлтүүд нь тэрхүү байгууллагын үйл ажиллагаа явуулдаг технологийн, хуулийн буюу засгийн газрын бодлогын орчинд тухайн тайлант үеийн туршид гарч тохиолдсон эсвэл ойрын ирээдүйд гарч тохиолдохоор байх.**

*Технологийн орчин*

ХЗУ2. Илүү сайн буюу үр ашигтай үйлчилгээ үзүүлэх өөр хувилбаруудыг бий болгох технологийн дэвшил гарсан бол хөрөнгийн үйлчилгээний хэрэгцээт

чанар буурч болох юм. Ийм маягаар үнэ цэнэ буурсан хөрөнгийн жишээнд дараах зүйлс хамаарна:

- (а) Илүү дэвшилтэй технологи бүхий шинэ төхөөрөмж нь илүү оновчтой оношилгооны үр дүн гаргах болсоноор эмнэлгийн оношилгооны тоног төхөөрөмжийг хаяа нэг ашигладаг буюу огт ашиглахаа больсон (энэ нь мөн дээрх (а)-д дурдсан шинж тэмдгүүдийг хангах юм);
- (б) Технологийн дэвшлийн улмаас гаднын нийлүүлэгч нь уг программ хангамжинд цаашид үйлчилгээ үзүүлэхээ больсон бөгөөд тухайн байгууллага нь тэрхүү программ хангамжийг хэвийн ажиллуулах боловсон хүчингүй байна;
- (в) Технологийн хөгжлийн улмаас компьютерийн техник хэрэгсэл нь хуучирч хоцрогдсон.

*Хуулийн буюу засгийн газрын бодлогын орчин*

ХЗУ3. Хууль буюу зохицуулалтын өөрчлөлтийн улмаас хөрөнгийн үйлчилгээний чадавхи буурч болох юм. Ийм шинж тэмдгээр тодорхойлогдох үнэ цэнийн бууралтын жишээнд дараах зүйлс хамаарна:

- (а) Утаа ялгаруулалтын шинэ стандартыг хангахгүй болсон автомашин эсвэл дуу чимээний шинэ стандартыг хангахгүй болсон онгоц;
- (б) Барилгын материал эсвэл аюулгүйн гарцын талаархи аюулгүй байдлын шинэ зохицуулалтын улмаас хичээл сургалтын зорилгоор цаашид ашиглах боломжгүй болсон сургууль;
- (в) Байгаль орчны шинэ стандартыг хангахгүй болсны улмаас цаашид ашиглах боломжгүй ундны усны үйлдвэр.

*Мэдээллийн дотоод эх сурвалж*

**(в) Хөрөнгийн биет эвдрэл, гэмтлийн талаархи нотолгоо байх.**

ХЗУ4. Биет эвдрэл, гэмтлийн улмаас хөрөнгө нь өөрийн үзүүлж байсан үйлчилгээний түвшинд хүрч чадахааргүй болсон. Ийм байдлаар үнэ цэнэ буурсан хөрөнгийн жишээнд дараах зүйлс хамаарна:

- (а) Гал, үер буюу бусад хүчин зүйлсийн улмаас эвдэрч гэмтсэн барилга;
- (б) Бүтцийн гажилтын улмаас ашиглахгүй болсон барилга;
- (в) Газрын хөрсний нуралтын улмаас овойж эвдэрсэн автозамын хэсэг. Замын ийм хэсгийг анхны төлөвлөсөн 30-н жилийн ашиглалтын дараа биш, харин 15 жилийн дараа сольж шинэчлэх шаардлагатай болсон;
- (г) Бүтцийн үнэлгээгээр ус зайлуулах суваг нь нарийссан гэдгийг тогтоосон далан;

- (д) Дамжуулах байгууламжийн бөглөрлийн улмаас хүчин чадал нь буурсан бөгөөд уг бөглөрлийг зайлуулах зардал нь эдийн засгийн үр ашиггүй байх ус цэвэршүүлэх байгууламж;
- (е) Бүтцийн гажилтын улмаас даацыг хязгаарласан гүүр;
- (ж) Мөргөлдөөний улмаас гэмтсэн цэргийн хөлөг онгоц;
- (и) Эвдэрч гэмтсэн бөгөөд засварлах боломжгүй эсвэл засварын зардал нь эдийн засгийн үр ашиггүй байх тоног төхөөрөмж.

**(г) Уг байгууллагад сөрөг нөлөөтэй урт хугацааны мэдэгдэхүйц өөрчлөлтүүд нь түүний хөрөнгөө ашиглаж байгаа эсвэл ашиглахаар хүлээгдэж буй хэмжээ, арга маягт гарч тохиолдсон эсвэл ойрын ирээдүйд гарахаар хүлээгдэж байх.**

ХЗУ5. Хөрөнгө нь үйлчилгээний чадавхиа хэвээр хадгалсаар байгаа боловч урт хугацааны өөрчлөлтүүд нь тухайн хөрөнгийг ашиглах хэмжээнд сөрөг нөлөөтэй байдаг. Ийм маягаар хөрөнгийн үнэ цэнэ буурч болох нөхцөл байдлын жишээнд дараах зүйлс хамаарна:

- (а) Хөрөнгийг анх ашиглалтанд оруулсан үеийнхтэй адил хэмжээгээр ашиглахгүй байгаа эсвэл тухайн хөрөнгийн хүлээгдэж буй ашиглалтын хугацаа нь анхны тооцоолсон хугацаанаас богино байвал хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болох юм. Ийм шинж тэмдгээр боломжит үнэ цэнийн бууралтыг тодорхойлж болох хөрөнгийн жишээнд бүрэн хүчин чадлаар ашигладаггүй мейнфрейм компьютер<sup>3</sup> хамаарна. Яагаад гэвэл, сервер буюу персональ компьютер дээр ажиллах хэрэглээний олон программ хангамжуудыг тэдгээрт зориулан боловсруулж эсвэл хөрвүүлэн ашиглах болсон. Хөрөнгийн үйлчилгээний эрэлтийн урт хугацааны мэдэгдэхүйц бууралт нь эргээд тухайн хөрөнгийн ашиглалтын хэмжээнд урт хугацааны мэдэгдэхүйц өөрчлөлт үүсгэж болох юм.
- (б) Хөрөнгийг анх ашиглалтанд оруулсан үеийнхтэй ижил арга замаар ашиглахгүй байгаа бол тухайн хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж

---

<sup>3</sup> Компьютерийг үүссэн цаг хугацаа, овор хэмжээ, үнээс хамааран мейнфрейм (mainframe), жижиг компьютер (minicomputer), бичил компьютер (microcomputer) гэж гурван янзаар нэрлэж байжээ. Мейнфрейм гэдэг нь их хэмжээний мэдээг боловсруулахын тулд том байгууллагуудын ашигладаг овор ихтэй, хүчин чадал өндөртэй компьютер юм. Энэ нь том төмөр шкафтай төстэй хэлбэртэй бөгөөд 1950-аад оны сүүлчээс эхлэн 1970-аад оныг хүртэл нийтлэг үйлдвэрлэгдэн хэрэглэгдэж байсан. Харин жижиг компьютер нь 1960-аад оны дунд үеэс үүсэж, 1985 он хүртэл идэвхитэй хэрэглэгдсэн бөгөөд мейнфрейм компьютерийн тэн хагас, түүнчлэн дөрөвний нэгээс бага хэмжээтэй ч байсан. Бичил буюу микро компьютер нь 1970-аад оны сүүлч, 1980-аад оноос үүссэн бөгөөд өртөг зардал, овор хэмжээ ихээхэн бага болсоноор өмнөх үеийн компьютерүүдээс давуу талтай юм. Ай Би Эм (IBM) корпораци нь тодорхой нэг хувь хүн болон бизнесийн хэрэгцээнд зориулсан өндөр хүчин чадалтай микро компьютерийг зохиож, түүнийгээ бусад микро компьютерүүдээс ялгахын тулд "персональ компьютер" (personal computer буюу товчоор PC) гэж нэрлэсэн. Үүний үр дүнд "микро" (бичил) компьютер хэллэг олон нийтийн дунд аажмаар хэрэглэгдэхээ больж, "PC" гэсэн нэршил түгээмэл болжээ. Ред.Ч.Д.

болох юм. Ийм шинж тэмдгээр тодорхойлж болох үнэ цэнэ буурсан хөрөнгийн жишээнд боловсролын зорилгоор биш, харин агуулахын зорилгоор ашиглаж буй сургуулийн барилга хамаарна.

**(д) Хөрөнгийг барьж байгуулах ажил дуусахаас эсвэл ашиглахад бэлэн болгохоос өмнө уг барилгын ажлыг зогсоох шийдвэр.**

ХЗУ6. Иж бүрэн болоогүй хөрөнгө нь түүний төлөвлөсөн үйлчилгээг үзүүлж чадахгүй юм. Ийм байдлаар үнэ цэнэ буурсан хөрөнгийн жишээнд дараах нөхцөл байдал дахь хөрөнгө хамаарна:

- (а) Устах аюулд орсон буюу нэн ховордсон төрөл зүйлийн амьдрах газар гэх мэт байгаль орчны нөхцөл байдал эсвэл археологийн олдвор олсны улмаас барилгын ажлыг зогсоосон;
- (б) Эдийн засгийн бууралтын улмаас барилгын ажлыг зогсоосон.

Барилгын ажлыг зогсооход хүргэх нөхцөл байдлуудыг мөн харгалзан үзнэ. Хэрэв барилгын ажлыг хойшлуулсан, өөрөөр хэлбэл ирээдүйн тодорхой хугацаа хүртэл түр зогсоосон бол уг төслийг дуусаагүй барилга гэж үзсэн хэвээр байх бөгөөд зогсоосон гэж үзэхгүй.

**(е) Хөрөнгийн үйлчилгээний гүйцэтгэл, үр дүн нь хүлээгдэж байснаас мэдэгдэхүйц муу байх эсвэл муу болно гэдгийг илтгэсэн нотолгоо дотоод тайлагналаас бий болсон байх.**

ХЗУ7. Хөрөнгө нь хүлээгдэж байсантай адил ажиллахгүй байгаа эсвэл түүний гүйцэтгэл нь цаг хугацааны явцад улам бүр муудаж байгаа гэдгийг дотоод тайлангаар илэрхийлсэн байж болох юм. Жишээлбэл; хөдөөний эмнэлэгт ашиглаж буй рентген зургийн аппаратын засвар, үйлчилгээний зардал нь анхны төсөвлөсөн дүнгээс мэдэгдэхүйц хэтэрсэн тул уг аппаратын үнэ цэнэ буурсан гэдгийг тус эмнэлгийн үйл ажиллагааны талаархи орон нутгийн эрүүл мэндийн хэлтсийн тайланд тэмдэглэсэн байж болно.

## Үлгэрчилсэн жишээ

*Эдгээр жишээ нь УСНББОУС 21-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### Үнэ цэнийн бууралтын гарзын хэмжилт

*Тэмдэглэл: Дараах жишээнүүдэд үнэ цэнийн бууралтыг нь сорьж буй тухайн хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ нь өөрөөр зааснаас бусад тохиолдолд түүний ашиглалтын үнэ цэнээс бага эсвэл үнэ цэнийг нь тодорхойлох боломжгүй байна гэж үзсэн. Иймээс хөрөнгийн нөхөгдөх үйлчилгээний дүн нь түүний ашиглалтын үнэ цэнэтэй тэнцүү байна. Эдгээр жишээний хувьд элэгдлийн шулуун шугамын аргыг ашиглана.*

### Элэгдэл тооцсон орлуулалтын өртгийн хандлага

*Байгууллагад сөрөг нөлөөтэй урт хугацааны мэдэгдэхүйц өөрчлөлтүүд нь технологийн орчинд гарч тохиолдсон – Бүрэн хүчин чадлаар ашигладаггүй мейнфрейм компьютер*

ҮЖ1. Керманн хот нь 1999 онд 10 сая ТН<sup>4</sup>-ээр шинэ мейнфрейм компьютер худалдан авсан. Керманн нь уг компьютерийн ашиглалтын хугацаа 7 жил байх бөгөөд төв боловсруулах нэгжийн (CPU) хүчин чадлын дундажаар 80-н хувийг янз бүрийн хэлтсүүд ашиглана гэж тооцоолж байсан. Харин оргил ачаалалтай үеийн тогтоосон хугацааны шаардлагыг хангахын тулд шахуу хуваарьт ажлуудыг гүйцэтгэхэд CPU-гийн 20 хувийн илүүдэл нөөцийг ашиглана гэж төлөвлөсөн. Худалдан авалт хийсний дараах хэдхэн сарын дотор CPU-ны ашиглалт 80 хувьд хүрсэн боловч хэлтсүүдийн хэрэглээний олон программ хангамжийг десктоп компьютер болон сервер дээр ажиллах боломжтой байдлаар хөрвүүлсэн учраас 2003 онд CPU-ны ашиглалт 20 хувь болж буурсан. Үлдсэн хэрэглээний программ хангамжуудыг ашигласнаар уг мейнфрейм компьютерийн үлдсэн үйлчилгээний чадавхийг бүрдүүлж чадах тийм компьютерийг зах зээлээс 500,000ТН-ээр авах боломжтой байна.

### Үнэ цэнийн бууралтын үнэлгээ

ҮЖ2. Үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг нь хэрэглээний программ хангамжуудыг мейнфрейм компьютерээс бусад жижиг компьютерт хөрвүүлэх, ингэснээр уг мейнфрейм компьютерийн ашиглалтыг бууруулахад хүргэх технологийн орчны урт хугацааны мэдэгдэхүйц өөрчлөлт юм (Нөгөө талаас, мейнфрейм компьютерийн ашиглалтын хэмжээний мэдэгдэхүйц бууралт нь үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг болно гэж хэлж болох юм). Элэгдэл тооцсон орлуулалтын өртгийн хандлагыг ашигласнаар үнэ цэнийн бууралтын гарзыг дараах байдлаар тодорхойлно:

---

<sup>4</sup> Эдгээр жишээнд мөнгөн дүнг “тооцооны нэгж” (ТН)-ээр илэрхийлсэн.

МӨНГӨ БИЙ БОЛГОДОГГҮЙ ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

<b>а</b>	<b>Худалдан авалтын өртөг, 1999 он</b>	<b>10,000,000</b>
	<b>Хуримтлагдсан элэгдэл, 2003 оны байдлаар</b>	<b>5,714,286</b>
	<b>(а х 4 : 7)</b>	
<b>б</b>	<b>Дансны үнэ, 2003 он</b>	<b>4,285,714</b>
<b>в</b>	<b>Орлуулалтын өртөг</b>	<b>500,000</b>
	<b>Хуримтлагдсан элэгдэл, (в х 4 : 7)</b>	<b>285,714</b>
<b>г</b>	<b>Нөхөгдөх үйлчилгээний дүн</b>	<b>214,286</b>
	<b>Үнэ цэнийн бууралтын гарз (б-г)</b>	<b>4,071,428</b>

*Мөнгө бий болгодоггүй хөрөнгөөр үзүүлэх үйлчилгээний эрэлт бараг зогссон – Бүрэн хүчин чадлаар ашигладаггүй мейнфрейм компьютерийн хэрэглээний программ хангамж*

ҮЖ3. 1999 онд Керманн хот нь өөрийн шинэ мейнфрейм компьютерийн хэрэглээний программ хангамжийн лицензийг 350,000ТН-ээр худалдан авсан. Керманн нь уг программ хангамжийн ашиглалтын хугацаа 7 жил байх бөгөөд түүний ашиглалтын хугацааны туршид программ хангамжаас эдийн засгийн үр өгөөж болон үйлчилгээний чадавхийг шулуун шугамын сууриар хүлээн авна гэж тооцоолж байсан. 2003 оны байдлаар хэрэглээний программ хангамжийн ашиглалт нь анхны төлөвлөсөн эрэлтийн 15 хувь болж буурсан. Уг үнэ цэнэ буурсан хэрэглээний программ хангамжийн үлдсэн үйлчилгээний чадавхийг орлуулан бүрдүүлэх тийм программ хангамжийн лиценз нь 70,000ТН-ийн өртөгтэй байна.

**Үнэ цэнийн бууралтын үнэлгээ**

ҮЖ4. Үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг нь мейнфрейм компьютерийн хүчин чадлын алдагдлаас шалтгаалсан технологийн өөрчлөлт юм.

<b>а</b>	<b>Худалдан авалтын өртөг, 1999 он</b>	<b>350,000</b>
	<b>Хуримтлагдсан элэгдэл, 2003 оны байдлаар</b>	<b>200,000</b>
	<b>(а х 4 : 7)</b>	
<b>б</b>	<b>Дансны үнэ, 2003 он</b>	<b>150,000</b>
<b>в</b>	<b>Орлуулалтын өртөг</b>	<b>70,000</b>
	<b>Хуримтлагдсан элэгдэл, (в х 4 : 7)</b>	<b>40,000</b>
<b>г</b>	<b>Нөхөгдөх үйлчилгээний дүн</b>	<b>30,000</b>
	<b>Үнэ цэнийн бууралтын гарз (б-г)</b>	<b>120,000</b>

*Байгууллагад сөрөг нөлөөтэй урт хугацааны мэдэгдэхүйц өөрчлөлтүүд нь түүний хөрөнгөө ашиглах арга маягт гарч тохиолдсон – Сургуулийн барилгыг агуулах байдлаар ашиглах*

ҮЖ5. 1997 онд Лүндений сургуулийн дүүрэг нь 10 сая ТН-ийн өртөгтэй бага сургууль барьсан. Сургуулийн тооцоолсон ашиглалтын хугацаа нь 50 жил

## МӨНГӨ БИЙ БОЛГОДОГГҮЙ ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

байсан. Тус дүүргийн гол ажил олгогч нь дампуурсаны улмаас хүн ам нь шилжин нүүж, тухайн дүүрэгт суралцагчдын тоо огцом буурснаар 2003 онд сургууль хаагдсан. Сургуулийн байрыг агуулахын зорилгоор ашиглах болсон бөгөөд Лүндений сургуулийн дүүрэг нь суралцагчдын тоо ирээдүйд нэмэгдэж, уг барилгыг сургуулийн зориулалтаар дахин нээнэ гэсэн хүлээлтгүй байна. Уг сургуультай ижил хүчин чадал бүхий агуулахын одоогийн орлуулалтын өртөг нь 4.2 сая ТН байна.

### Үнэ цэнийн бууралтын үнэлгээ

ҮЖ6. Сургуулийн зориулалттай байрыг агуулах болгож, уг барилгыг ашиглах зориулалтыг эрс өөрчилсөн бөгөөд ойрын ирээдүйд үүнийг буцаан өөрчлөх төлөвгүй учраас үнэ цэнийн бууралтыг илэрхийлнэ. Элэгдэл тооцсон орлуулалтын өртгийг ашиглан үнэ цэнийн бууралтын гарзыг дараах байдлаар тодорхойлсон:

<b>а</b>	<b>Түүхэн өртөг, 1997 он</b>	<b>10,000,000</b>
	<b>Хуримтлагдсан элэгдэл, 2003 оны байдлаар</b>	<b>1,200,000</b>
	<b>(а х 6 : 50)</b>	
<b>б</b>	<b>Дансны үнэ, 2003 он</b>	<b>8,800,000</b>
<b>в</b>	<b>Ижил хүчин чадалтай агуулахын барилгын орлуулалтын өртөг</b>	<b>4,200,000</b>
	<b>Хуримтлагдсан элэгдэл, (в х 6 : 50)</b>	<b>504,000</b>
<b>г</b>	<b>Нөхөгдөх үйлчилгээний дүн</b>	<b>3,696,000</b>
	<b>Үнэ цэнийн бууралтын гарз (б-г)</b>	<b>5,104,000</b>

*Байгууллагад сөрөг нөлөөтэй урт хугацааны мэдэгдэхүйц өөрчлөлтүүд нь түүний хөрөнгөө ашиглах хэмжээнд гарч тохиолдсон – Суралцагчдын тоо буурсны улмаас сургууль хэсэгчлэн хаагдсан*

ҮЖ7. 1983 онд Лүттон сургуулийн дүүрэг нь 2.5 сая ТН-ийн өртөгтэй сургууль барьсан. Тус байгууллага нь сургуулийг 40 жил ашиглана гэж тооцоолсон. Тус дүүргийн гол ажил олгогч нь дампуурсаны улмаас хүн ам нь шилжин нүүж, тухайн дүүрэгт суралцагчдын тоо 2003 онд 1,000-аас 200 болтол буурсан. Удирдлага нь гурван давхар сургуулийн барилгын дээд талын хоёр давхарыг хаахаар шийдвэрлэсэн. Лүттоны сургуулийн дүүрэг нь суралцагчдын тоо ирээдүйд нэмэгдэж, уг барилгын дээд давхаруудыг дахин нээнэ гэсэн хүлээлтгүй байна. Нэг давхар сургуулийн барилгын одоогийн орлуулалтын өртөг нь 1.3 сая ТН гэж тооцоолсон.

### Үнэ цэнийн бууралтын үнэлгээ

ҮЖ8. Суралцагчдын тоо 1,000-аас 200 болж буурснаар сургуулийн ашиглалтын хэмжээ нь гурван давхар байснаа нэг давхар болж өөрчлөгдсөн тул үнэ цэнийн бууралтыг илэрхийлнэ. Ашиглалтын хэмжээний уг бууралт нь мэдэгдэхүйц хэмжээтэй бөгөөд суралцагчдын тоо нь ойрын ирээдүйд энэхүү буурсан түвшинд хэвээр байхаар хүлээгдэж байна. Элэгдэл

МӨНГӨ БИЙ БОЛГОДОГГҮЙ ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

тооцсон орлуулалтын өртгийн хандлагыг ашиглан үнэ цэнийн бууралтын гарзыг дараах байдлаар тодорхойлсон:

а	Түүхэн өртөг, 1983 он	2,500,000
	Хуримтлагдсан элэгдэл, 2003 оны байдлаар (а х 20 : 40)	1,250,000
б	Дансны үнэ, 2003 он	<u>1,250,000</u>
в	Орлуулалтын өртөг	1,300,000
	Хуримтлагдсан элэгдэл, (в х 20 : 40)	650,000
г	Нөхөгдөх үйлчилгээний дүн	<u>650,000</u>
	Үнэ цэнийн бууралтынгарз (б-г)	<u><u>600,000</u></u>

**Нөхөн сэргээлтийн өртгийн хандлага**

*Биет эвдрэл, гэмтэл – Сургуулийн автобус нь замд осолд эвдэрсэн*

ҮЖ9. 1998 онд Норф дүүргийн бага сургууль нь ойролцоо тосгоноос ирэх сурагчдад үнэгүй үйлчлэхийн тулд 200,000ТН-ээр автобус худалдан авсан. Уг сургууль нь автобусны ашиглалтын хугацааг 10 жил гэж тооцоолсон. 2003 онд автобус нь замын осолд орж, эвдэрсэн бөгөөд ашиглалтын хэвийн байдалд оруулахын тулд 40,000ТН зарцуулах шаардлагатай болсон. Ингэж нөхөн сэргээх нь уг автобусны ашиглалтын хугацаанд нөлөө үзүүлэхгүй юм. Ижил үйлчилгээ үзүүлэх шинэ автобусны өртөг нь 2003 онд 250,000ТН байсан.

**Үнэ цэнийн бууралтын үнэлгээ**

ҮЖ10. Замын ослын улмаас автобус биетээр эвдэрсэн тул үнэ цэнийн бууралтыг илэрхийлнэ. Нөхөн сэргээлтийн өртгийн хандлагыг ашигласнаар үнэ цэнийн бууралтын гарзыг дараах байдлаар тодорхойлно:

а	Худалдан авалтын өртөг, 1998 он	200,000
	Хуримтлагдсан элэгдэл, 2003 оны байдлаар (а х 5 : 10)	100,000
б	Дансны үнэ, 2003 он	<u>100,000</u>
в	Орлуулалтын өртөг	250,000
	Хуримтлагдсан элэгдэл, (в х 5 : 10)	125,000
г	Элэгдэл тооцсон орлуулалтын өртөг (эвдрээгүй төлөв байдалд)	125,000
	Хасах: нөхөн сэргээлтийн өртөг	40,000
д	Нөхөгдөх үйлчилгээний дүн	<u>85,000</u>
	Үнэ цэнийн бууралтынгарз (б-г)	<u><u>15,000</u></u>



*Биет эвдрэл, гэмтэл – Галд өртсөн барилга*

ҮЖ11. 1984 онд Моорланд хот нь 50 сая ТН-ийн өртгөөр оффисын барилга барьсан. Барилга нь 40 жил ашиглагдана гэж тооцоолж байсан. Ашиглалтанд орсноос хойш 19 жийн дараа буюу 2003 онд гал гарсаны улмаас барилгын бүтцэд ноцтой асуудал үүссэн. Аюулгүй байдлын үүднээс уг оффисын барилгыг хаасан бөгөөд ашиглаж болох хэвийн нөхцөл байдалд тэрхүү барилгыг нөхөн сэргээхийн тулд 35.5 сая ТН-ийн бүтцийн засвар хийх шаардлагатай болсон. Шинэ оффисын барилгын орлуулалтын өртөг нь 100 сая ТН байсан.

**Үнэ цэнийн бууралтын үнэлгээ**

ҮЖ12. Галын улмаас оффисын барилгад биет гэмтэл үүссэн тул үнэ цэнийн бууралтыг илэрхийлнэ. Нөхөн сэргээлтийн өртгийн хандлагыг ашигласнаар үнэ цэнийн бууралтын гарзыг дараах байдлаар тодорхойлно:

<b>а</b>	<b>Түүхэн өртөг, 1984 он</b>	<b>50,000,000</b>
	<b>Хуримтлагдсан элэгдэл, 2003 оны байдлаар</b>	<b>23,750,000</b>
	<b>(а х 19 : 40)</b>	
<b>б</b>	<b>Дансны үнэ, 2003 он</b>	<b><u>26,250,000</u></b>
<b>в</b>	<b>Орлуулалтын өртөг (шинэ барилгын)</b>	<b>100,000,000</b>
	<b>Хуримтлагдсан элэгдэл, (в х 19 : 40)</b>	<b>47,500,000</b>
<b>г</b>	<b>Элэгдэл тооцсон орлуулалтын өртөг</b>	<b>52,500,000</b>
	<b>(гэмтээгүй төлөв байдалд)</b>	
	<b>Хасах: нөхөн сэргээлтийн өртөг</b>	<b>35,500,000</b>
<b>д</b>	<b>Нөхөгдөх үйлчилгээний дүн</b>	<b><u>17,000,000</u></b>
	<b>Үнэ цэнийн бууралтынгарз (б-г)</b>	<b><u>9,250,000</u></b>

**Үйлчилгээний нэгжийн хандлага**

*Байгууллагад сөрөг нөлөөтэй урт хугацааны мэдэгдэхүйц өөрчлөлтүүд нь түүний хөрөнгөө ашиглах хэмжээнд гарч тохиолдсон – Ойрын ирээдүйд хэсэгчлэн ашиглагдахгүй болсон өндөр барилга*

ҮЖ13. 1988 онд Орнон хотын Зөвлөл нь өөрөө ашиглах зорилгоор 20 давхар оффисын барилгыг тус хотын төвд 80 сая ТН-ийн өртөгтэйгээр барьсан. Барилгын ашиглалтын хугацаа нь 40 жил гэж тооцоолж байсан. 2003 онд Үндэсний аюулгүйн байдлын журмаар уг өндөр барилгын дээд талын 4-н давхарыг тодорхой бус хугацаанд ашиглахгүй байхыг шаардсан. Ийм шийдвэр гарсаны дараа уг барилгын борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ нь 2003 онд 45 сая ТН болсон. Үүнтэй ижил 20 давхар барилгын одоогийн орлуулалтын өртөг нь 85 сая ТН байна.

**Үнэ цэнийн бууралтын үнэлгээ**

ҮЖ14. Үндэсний аюулгүйн байдлын шинэ журмын улмаас тус оффисын барилгын ашиглалтын хэмжээг 20 давхараас 16 давхар болгон өөрчилсөн тул үнэ цэнийн бууралтыг илэрхийлнэ. Ашиглалтын хэмжээний уг бууралт нь мэдэгдэхүйц хэмжээтэй бөгөөд барилгын ашиглалт нь ойрын ирээдүйд энэхүү буурсан түвшинд (16 давхарын) хэвээр байхаар хүлээгдэж байна. Үйлчилгээний нэгжийн хандлагыг ашиглан үнэ цэнийн бууралтын гарзыг дараах байдлаар тодорхойлсон:

<b>а</b>	<b>Худалдан авалтын өртөг, 1988 он</b>	<b>80,000,000</b>
	<b>Хуримтлагдсан элэгдэл, 2003 оны байдлаар</b>	<b>30,000,000</b>
	<b>(а х 15 : 40)</b>	
<b>б</b>	<b>Дансны үнэ, 2003 он</b>	<b>50,000,000</b>
<b>в</b>	<b>Орлуулалтын өртөг (20 давхар барилга)</b>	<b>85,000,000</b>
	<b>Хуримтлагдсан элэгдэл, (в х 15 : 40)</b>	<b>31,875,000</b>
<b>г</b>	<b>Элэгдэл тооцсон орлуулалтын өртөг</b>	<b>53,125,000</b>
	<b>(үлдсэн үйлчилгээний нэгжийн хувьд тохируулга хийхийн өмнөх)</b>	
<b>д</b>	<b>Журам хүчин төгөлдөр болсны дараах уг барилгын ашиглалтын үнэ цэнэ (г х 16 : 20)</b>	<b>42,500,000</b>
<b>е</b>	<b>Журам хүчин төгөлдөр болсны дараах уг барилгын борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ</b>	<b>45,000,000</b>
<b>ж</b>	<b>Нөхөгдөх үйлчилгээний дүн</b>	<b>45,000,000</b>
	<b>(“д” ба “е”-гийн аль өндөр нь)</b>	
	<b>Үнэ цэнийн бууралтынгарз (б-ж)</b>	<b>5,000,000</b>

*Дотоод тайлагналын нотолгоо – Хэвлэлийн машиныг ажиллуулах өндөр зардал*

ҮЖ15. 1998 онд “Х” орон нутгийн Боловсролын газар нь шинэ хэвлэлийн машиныг 40 сая ТН-ээр худалдан авсан. Уг машин нь бага сургуулийн сурагчдын ашиглах номыг 10 жилийн хугацаанд 40 сая хувь хэвлэх ашиглалтын хугацаатай гэж тус Боловсролын газар тооцоолж байсан. Хэвлэлийн машины автомат ажиллагаа нь хүлээгдэж байсны дагуу ажиллахгүй учраас тэрхүү хөрөнгийн ашиглалтын үлдсэн 5 жилийн хугацаанд машины жил тутмын гарцын түвшин 25 хувиар буурна гэдгийг 2003 онд тайлагнасан. Шинэ хэвлэлийн машины орлуулалтын өртөг нь 2003 онд 45 сая ТН байсан.

**Үнэ цэнийн бууралтын үнэлгээ**

ҮЖ16. Хэвлэлийн машины гүйцэтгэл, үр дүн нь хүлээгдэж байснаас муу байгаа гэсэн дотоод тайлагналын нотолгоо нь түүний үнэ цэнэ буурсныг

МӨНГӨ БИЙ БОЛГОДОГГҮЙ ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

илэрхийлж байна. Уг хөрөнгийн үйлчилгээний чадавхийн бууралт нь мэдэгдэхүйц нөлөөтэй бөгөөд урт хугацааны шинжтэй гэдгийг нөхцөл байдал харуулж байна. Үйлчилгээний нэгжийн хандлагыг ашигласнаар үнэ цэнийн бууралтын гарзыг дараах байдлаар тодорхойлсон:

<b>а</b>	<b>Худалдан авалтын өртөг, 1998 он</b>	<b>40,000,000</b>
	<b>Хуримтлагдсан элэгдэл (а х 5 : 10)</b>	<b><u>20,000,000</u></b>
<b>б</b>	<b>Дансны үнэ, 2003 он</b>	<b><u>20,000,000</u></b>
<b>в</b>	<b>Орлуулалтын өртөг</b>	<b>45,000,000</b>
	<b>Хуримтлагдсан элэгдэл, (в х 5 : 10)</b>	<b><u>22,500,000</u></b>
<b>г</b>	<b>Элэгдэл тооцсон орлуулалтын өртөг</b>	<b>22,500,000</b>
	<b>(үлдсэн үйлчилгээний нэгжийн хувьд тохируулга хийхийн өмнөх)</b>	<b>_____</b>
<b>д</b>	<b>Нөхөгдөх үйлчилгээний дүн (г х 75%)</b>	<b><u>16,875,000</u></b>
	<b>Үнэ цэнийн бууралтын гарз (б-д)</b>	<b><u>3,125,000</u></b>

## НББОУС 36 (2004)-ТАЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 21-ийг НББОУС 36 (2004)-гаас үндсэндээ бэлтгэсэн. УСНББОУС 21 ба НББОУС 36 (2004)-гийн хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- НББОУС 36 нь ашгийн төлөө аж ахуйн нэгжүүдийн мөнгө бий болгогч хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг авч үздэг бол УСНББОУС 21 нь улсын секторын байгууллагуудын мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг харгалзан үздэг.
- УСНББОУС 17-д заасан зөвшөөрөгдсөн сонголтот аргын дагуу тухайн тайлангийн өдрөөр дахин үнэлсэн дүнгээр бүртгэдэг мөнгө бий болгодоггүй хөрөнгийн хувьд УСНББОУС 21-ийг мөрддөггүй. Харин НББОУС 36 нь тухайн тайлангийн өдрөөр дахин үнэлсэн дүнгээр бүртгэсэн мөнгө бий болгогч үндсэн хөрөнгийг өөрийн цар хүрээнээс хасдаггүй.
- УСНББОУС 21-ийн дагуу мөнгө бий болгодоггүй хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг хэмжих арга нь НББОУС 36-гийн дагуу мөнгө бий болгогч хөрөнгөнд хэрэглэх аргаас өөр байдаг. УСНББОУС 21 нь мөнгө бий болгодоггүй хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг олон хандлагуудыг ашигласнаар тухайн хөрөнгийн үлдсэн үйлчилгээний чадавхийн өнөөгийн үнэ цэнэ байдлаар хэмждэг. НББОУС 36 нь мөнгө бий болгогч хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг тухайн хөрөнгөөс бий болох ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ байдлаар хэмждэг.
- УСНББОУС 21 нь хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийн өөрчлөлтийг тод хар үсгээр үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг болгон тусгаагүй. Зах зээлийн үнэ цэнийн хүлээгдээгүй, мэдэгдэхүйц бууралтыг НББОУС 36-д үнэ цэнийн бууралтын хамгийн наад захын цогц шинж тэмдгийн нэг хэсэг байдлаар тод хар үсгээр харуулсан бол УСНББОУС 21 нь үүнийг тайлбар хэсэгт оруулсан.
- УСНББОУС 21 нь хөрөнгийг барьж байгуулах ажил дуусахаас өмнө уг барилгын ажлыг зогсоох шийдвэрийг тод хар үсгээр үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг болгон, харин хөрөнгийн барилгын ажлыг дахин эхлүүлэлтийг үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтын шинж тэмдэг байдлаар тусгасан. Харин НББОУС 36-д үүнтэй адилтгах заалт байдаггүй.
- УСНББОУС 21-ийн цар хүрээнд хамаарах хөрөнгийн зарим ангиудыг НББОУС 36-гийн цар хүрээнд хамруулдаггүй. Ийм үл хамруулалт нь бусад СТОУС-ын дагуу үнэ цэнийн бууралтын тусгай шаардлагуудад хамаарах тийм хөрөнгийн ангиудтай холбоотой байдаг. Ийм адилтгах УСНББОУС-ууд байхгүй учраас тэдгээр хөрөнгийн ангиудыг УСНББОУС 21-ээс хасаагүй. НББОУС 36-гийн цар хүрээнд үл хамаарах хөрөнгийн ангиуд нь (а) хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой биологийн хөрөнгө, (б) хойшлогдсон татварын хөрөнгө, (в) хойшлогдсон худалдан авалтын өртөг, (г) СТОУС 4, *Даатгалын Гэрээ*-ний цар хүрээнд

хамаарах даатгалын гэрээний дагуу даатгагчийн гэрээнийн эрхээс үүсэх биет бус хөрөнгө, (д) СТОУС 5, *Борлуулах Зорилгоор Эзэмшиж Буй Эргэлтийн Бус Хөрөнгө ба Зогсоосон Үйл Ажиллагаа*-ны дагуу борлуулах зорилгоор эзэмшиж байгаа гэж ангилсан эргэлтийн бус хөрөнгө (буюу данснаас хасах бүлгүүд) юм.

- УСНББОУС 21 нь бие даасан хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралтыг авч үздэг. НББОУС 36-д тодорхойлсонтой адил мөнгө бий болгогч нэгжид зориулсан адилтгах заалт УСНББОУС 21-д байдаггүй.
- УСНББОУС 21 нь корпорацийн хөрөнгийг мөнгө бий болгодоггүй бусад хөрөнгөтэй ижил арга замаар авч үздэг бол НББОУС 36 нь тэдгээрийг холбогдох мөнгө бий болгогч нэгжийн нэг хэсэг байдлаар тайлагнадаг.
- УСНББОУС 21 нь зарим тохиолдолд НББОУС 36-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь УСНББОУС 21 дэх “орлого” /revenue/, “нөхөгдөх үйлчилгээний дүн”, “санхүүгийн үр дүнгийн тайлан” гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. НББОУС 36 дахь адилтгах нэр томъёо нь “орлого” /income/, “нөхөгдөх дүн”, “орлогын тайлан” юм.

## УСНББОУС 22–ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНДСЭН СЕКТОРЫН ТАЛААРХИ САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОДРУУЛГА

### УСНББОУС-ын түүх

Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

УСНББОУС 22, Засгийн Газрын Үндсэн Секторын Талаархи Санхүүгийн Мэдээллийн Тодруулга-ыг 2006 оны 12 дугаар сард гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 22-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 35, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2011-ийн Сайжруулалтууд (2011 оны 10 дугаар сард гаргасан)

### УСНББОУС 22-ын нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт

Өөрчлөгдсөн параграф	Хэрхэн өөрчилсөн	Юугаар өөрчилсөн
Танилцуулга хэсэг	Хассан	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
3	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
13	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
16	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
22	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
24	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
26	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
27	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар

29	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
30	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
41	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
47А	Шинэ	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
47Б	Шинэ	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
47В	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
47Г	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
48	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар

2006 оны 12 дугаар сар

**УСНББОУС 22–ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНДСЭН СЕКТОРЫН  
ТАЛААРХИ САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОДРУУЛГА**

**АГУУЛГА**

---

	Параграф
Зорилго	1
Цар хүрээ	2-14
Сегментийн тайлагнал	7-8
Санхүүгийн тайлагналын статистикийн сууриуд	9-11
Нягтлан бодох бүртгэлийн бодлого	12-14
Тодорхойлолт	15-22
Улсын Үйлдвэрийн Газар	16
Засгийн газрын үндсэн сектор	17-22
Улсын санхүүгийн корпорацийн сектор	19
Улсын санхүүгийн бус корпорацийн сектор	20-22
Нягтлан бодох бүртгэлийн бодлого	23-34
Дэлгэрэнгүй задаргаа	33-34
Тодруулга	35-46
Нэгтгэсэн санхүүгийн тайлантай хийх тохируулга	43-44
Санхүүгийн тайлагналын статистикийн сууриудтай хийх тохируулга	45-46
Хүчин төгөлдөр болох хугацаа	47-48
Дүгнэлтийн үндэслэл	
Хэрэгжүүлэх заавар удирдамж	



ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНДСЭН СЕКТОРЫН ТАЛААРХИ  
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОДРУУЛГА

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 22, *Засгийн Газрын Үндсэн Секторын Талаархи Санхүүгийн Мэдээллийн Тодруулга*-ыг 1-48-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 22-ыг түүний зорилгын агуулга, Дүгнэлтийн Үндэслэл, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

1. Энэ Стандартын зорилго нь засгийн газрын үндсэн сектор (ЗГҮС)-ын талаархи мэдээллийг өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайландаа толилуулах сонголт хийсэн засгийн газруудын хувьд тодруулгын шаардлагыг тодорхойлоход оршино. Засгийн газрын ЗГҮС-ын талаархи зохих мэдээллийн тодруулга нь санхүүгийн тайлан илтгэлийн ил тод ойлгомжтой байдлыг нэмэгдүүлж, засгийн газрын зах зээлийн болон зах зээлийн бус үйл ажиллагааны хоорондох, түүнчлэн санхүүгийн тайлан ба санхүүгийн тайлагналын статистикийн сууриуд хоорондох уялдаа холбооны талаар илүү сайн ойлголтыг бий болгох юм.

## Цар хүрээ

2. **Нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар нэгтгэсэн санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг бөгөөд засгийн газрын үндсэн секторын талаархи санхүүгийн мэдээллийг тодруулах сонголт хийсэн засгийн газар нь түүндээ энэ Стандартын шаардлагуудыг мөрдөнө.**
3. Засгийн газрууд нь өөрсдийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаагаа санхүүжүүлэхийн тулд татвар, шилжүүлэг, түүнчлэн зах зээлийн болон зах зээлийн бус төрөл бүрийн үйл ажиллагаанаас мөнгө санг бүрдүүлдэг. Засгийн газар нь өөрийн иргэддээ бараа, үйлчилгээ нийлүүлэхийн тулд янз бүрийн олон байгууллагуудаар дамжуулан үйл ажиллагаагаа явуулдаг. Зарим байгууллага нь өөрсдийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэхийн тулд татварын болон засгийн газрын бусад орлогын төсвийн хуваарилалт буюу хуваарилалтанд үндсэндээ найддаг боловч орлого бий болгох нэмэлт үйл ажиллагааг, үүн дотроо зарим тохиолдолд арилжааны үйл ажиллагааг бас эрхлэн явуулж болох юм. Өөр зарим байгууллагууд нь өөрсдийн мөнгө санг үндсэндээ буюу ихэнхдээ арилжааны үйл ажиллагаанаас бүрдүүлдэг байж болох юм.
4. УСНББОУС-ын дагуу бэлтгэсэн засгийн газрын санхүүгийн тайлан нь (а) засгийн газрын хяналтанд буй хөрөнгө ба хариуцах өр төлбөр, (б) засгийн газрын үзүүлсэн үйлчилгээний өртөг, (в) тэдгээр үйлчилгээний нийлүүлэлтийг санхүүжүүлэхийн тулд бүрдүүлсэн татварын болон бусад орлогын талаархи тойм мэдээллийг харуулдаг. Хяналтанд буй байгууллага нь өөрсдийн үйл ажиллагааг санхүүжүүлэхийн тулд уг засгийн газрын төсвөөс үндсэндээ хамааралтай байдаг эсэхээс үл хамааран тэдгээр хяналтан буй байгууллагуудаар дамжуулан үйлчилгээгээ үзүүлдэг засгийн газрын хувьд санхүүгийн тайлан нь нэгтгэсэн санхүүгийн тайлан байна.
5. Зарим улс оронд, засгийн газрын буюу түүний секторуудын санхүүгийн тайлан болон төсвийг санхүүгийн тайлагналын статистикийн сууриудын дагуу бас бэлтгэж болох юм. Эдгээр сууриуд нь Нэгдсэн Үндэстний Байгууллага болон олон улсын бусад байгууллагуудаас гаргасан *Үндэсний Тооцооны Систем 1993* (ҮТС 93)-д үндэслэсэн ба түүнтэй

## ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНДСЭН СЕКТОРЫН ТАЛААРХИ САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОДРУУЛГА

нийцсэн байх шаардлагуудыг тусгадаг. Санхүүгийн тайлагналын эдгээр статистикийн сууриуд нь ЗГҮС-ын талаархи санхүүгийн мэдээлэл бэлтгэлтэнд голчлон чиглэгддэг. ЗГҮС нь ашгийн төлөө бус байгууллагуудаас бүрддэг бөгөөд тэдгээр байгууллагууд нь зах зээлийн бус үйл ажиллагаа явуулж, өөрсдийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэхийн тулд засгийн газрын төсвийн хуваарилалт буюу хуваарилалтанд юуны өмнө найдлага тавьдаг (цаашид зах зээлийн бус байгууллага буюу үйл ажиллагаа гэж нэрлэнэ). Санхүүгийн тайлагналын статистикийн сууриуд нь (а) үндсэндээ зах зээлийн үйл ажиллагаа явуулдаг засгийн газрын корпорацийн сектор (улсын санхүүгийн корпорацийн (УСК) сектор ба улсын санхүүгийн бус корпорацийн сектор (УСБКС) гэж ихэвчлэн нэрлэдэг), (б) бүхэлдээ улсын секторын талаархи мэдээллээр мөн хангадаг байж болох юм. УСК-ийн болон УСБК-ийн секторуудын гол шинж чанаруудыг энэхүү Стандартын 19 ба 20-р параграфт авч үзсэн.

6. Зөвхөн хяналтанд буй байгууллагуудыг санхүүгийн тайланд нэгтгэдэг. Санхүүгийн тайлагналын статистикийн сууриудын хувьд ийм хязгаарлалт тогтоодоггүй. Зарим улс оронд, үндэсний засгийн газар нь мужийн/бүсийн болон орон нутгийн засгийн газрын байгууллагуудыг хянадаг, иймээс өөрийн санхүүгийн тайландаа засгийн газрын тэдгээр түвшингүүдийг нэгтгэдэг бол өөр бусад оронд ингэж нэгтгэдэггүй. Бүх улс орны хувьд санхүүгийн тайлагналын статистикийн сууриудын дагуу засгийн газрын бүх түвшний ЗГҮС-ыг нэгтгэн нийлүүлдэг, иймээс зарим улс оронд ЗГҮС нь санхүүгийн тайлангаа нэгтгэдэггүй нэгжүүдийг ч тусгасан байдаг. Энэ Стандарт нь засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланг салган задалж авч үздэггүй. Иймээс засгийн газрын санхүүгийн тайланд тусган нэгтгэдэггүй аливаа байгууллагыг ЗГҮС-ын нэг хэсэг байдлаар толилуулахыг энэ Стандартаар хориглодог.

### **Сегментийн тайлагнал**

7. Хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгоор УСНББОУС 18, “Сегментийн Тайлагнал” нь тухайн байгууллагын үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны болон тэдгээр үйл ажиллагааг дэмжихийн тулд хуваарилсан нөөцийн талаархи зарим мэдээллийн хувьд тодруулга хийхийг шаарддаг. Санхүүгийн тайлагналын статистикийн сууриудын дагуу тайлагнасан секторуудаас ялгаатай нь, УСНББОУС 18-ын дагуу тайлагнасан сегментүүд нь зах зээлийн ба зах зээлийн бус үйл ажиллагааны хоорондох ялгаатай байдалд үндэслэдэггүй.
8. ЗГҮС-ын талаархи мэдээллийн тодруулга нь УСНББОУС 18-ын дагуу сегментийн талаар тодруулга хийх хэрэгцээ шаардлагыг орлохгүй юм. Яагаад гэвэл, тухайн байгууллага нь өөрийн үйлчилгээ үзүүлэх гол зорилтуудыг ЗГҮС-ын бус байгууллагуудаар дамжуулан хэрэгжүүлсэн тохиолдолд зөвхөн ЗГҮС-ын талаархи мэдээлэл нь уг зорилгод хүрэх тэрхүү байгууллагын өмнөх гүйцэтгэлийг үнэлэх боломжийг хэрэглэгчдэд олгохуйц хангалттай дэлгэрэнгүй байдаггүй. Жишээлбэл; засгийн газрын корпорациуд буюу бүрэн бус корпорациуд нь шуудан холбоо, эрүүл мэнд,

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНДСЭН СЕКТОРЫН ТАЛААРХИ  
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОДРУУЛГА

боловсролын зорилтуудтай холбоотой үйлчилгээг үзүүлдэг тохиолдолд ЗГҮС-ыг сегмент гэж тодорхойлох нь тэдгээр зорилтуудад хүрэх уг засгийн газрын гүйцэтгэлийн талаархи мэдээллээр хангахгүй. ЗГҮС нь нийт засгийн газрын зөвхөн нэг дэд хэсэг учраас засгийн газар нь өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд сегментийн мэдээллийг толилуулахгүй бол чухал ач холбогдолтой мэдээллийг орхигдуулах юм.

**Санхүүгийн тайлагналын статистикийн сууриуд**

9. УСНББОУС-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайлангийн зорилго нь санхүүгийн тайлагналын статистикийн сууриудын дагуу бэлтгэсэн тайлангийн зорилгоос зарим талаар ялгаатай байдаг. УСНББОУС-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайлангийн зорилго нь шийдвэр гаргалтанд ач холбогдолтой мэдээллээр хангах, түүнчлэн тухайн байгууллагад итгэн өгсөн болон түүний хяналатнд буй нөөцийн хувьд уг байгууллагын хариуцлагатай байдлыг харуулахад оршино. Санхүүгийн тайлагналын статистикийн сууриудын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайлангийн зорилго нь төсвийн бодлогыг, ялангуяа ЗГҮС-ын болон аливаа улс орны нийт улсын секторын гүйцэтгэлийг шинжилж, үнэлэхэд тохиромжтой мэдээллээр хангах явдал юм. Мөн түүнчлэн, санхүүгийн тайлагналын статистикийн сууриудыг нягтлан бодох бүртгэлийн нэр томъёогоор илэрхийлж болох боловч тэдгээр нь засгийн газрын санхүүгийн талаархи ихэнх статистик мэдээг бэлтгэдэг уг санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн суурь системээс олон талаар өөр байж болох юм. Гэвч УСНББОУС-ууд болон санхүүгийн тайлагналын статистикийн сууриуд нь ажил гүйлгээ ба үйл явдлыг тайлагнахад олон талаар ижил төсөөтэй байдаг. Жишээлбэл; эдгээр нь нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийг мөрддөг, ижил төсөөтэй ажил гүйлгээ ба үйл явдлыг тайлагнадаг бөгөөд зарим талаар ижил төсөөтэй тайлангийн бүтцийг шаарддаг.
10. Зарим улс оронд, ЗГҮС-ын талаархи зохих мэдээллийн санхүүгийн тайлангийн тодруулга нь тэдгээр санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн шийдвэр гаргалт болон хариуцлагатай байдлыг сайжруулж, дэмжлэг үзүүлдэг. Жишээлбэл; ЗГҮС-ын талаархи мэдээллийн тодруулга нь санхүүгийн тайлагналын ил тод, ойлгомжтой байдлын сайжруулалттай нийцдэг бөгөөд дараах зүйлсийг илүү сайн ойлгоход санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд тусалдаг:
  - (а) ЗГҮС-ын үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхийн тулд хуваарилсан нөөц ба тэдгээр үйлчилгээг үзүүлэх уг засгийн газрын санхүүгийн гүйцэтгэл, үр дүн; ба
  - (б) ЗГҮС ба корпорацийн секторуудын хоорондох уялдаа хамаарал, түүнчлэн ерөнхий санхүүгийн гүйцэтгэлд тэдгээрийн тус тусын үзүүлэх нөлөө.
11. Засгийн газрын санхүүгийн тайланг санхүүгийн тайлагналын статистикийн сууриудтай нийцүүлэн бэлтгэдэг бөгөөд олон нийтэд хэвлэн танилцуулдаг улс орнуудын хувьд, ЗГҮС-ын талаархи мэдээллийн санхүүгийн тайлан дахь тодруулга нь УСНББОУС-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайлан ба

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНДСЭН СЕКТОРЫН ТАЛААРХИ  
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОДРУУЛГА

санхүүгийн тайлагналын статистикийн сууриудын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайлангийн хоорондох чухал ач холбогдолтой холбоосыг бий болгодог. Энэ нь санхүүгийн тайланд толилуулсан мэдээллийг статистикийн тайланд толилуулсан мэдээлэлтэй тохируулахад хэрэглэгчдэд тусалдаг. УСНББОУС 24, *Санхүүгийн Тайлан дахь Төсвийн Мэдээллийн Толилуулга* нь төсөвт хэрэглэсэн суурьтай нийцсэн сууриар бэлтгэсэн гүйцэтгэлийн дүн ба төсвийн хоорондох зэрэгцүүлэлтийг санхүүгийн тайланд тусгахыг шаарддаг. Засгийн газрын төсвийг нийт засгийн газрын түвшинд биш, харин ЗГҮС-ын хувьд бэлтгэдэг тохиолдолд энэ Стандартын дагуу толилуулсан ЗГҮС-ын талаархи санхүүгийн мэдээлэл нь тэрхүү УСНББОУС-аар шаардсан зэрэгцүүлэлтэнд хамааралтай байдаг.

**Нягтлан бодох бүртгэлийн бодлого**

12. Санхүүгийн тайлан нь олон тооны чанарын шинжүүдийг хангасан мэдээллийг бэлтгэдэг гэдгийг ханган магадлахын тулд нягтлан бодох бүртгэлийн бодлого боловсруулахыг УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын өөрчлөлт ба Алдаа*-аар шаардсан байдаг. Санхүүгийн тайланд толилуулсан мэдээллийн чанарын шинжүүд, түүнчлэн холбогдох аудитын шаардлагуудыг хангах ЗГҮС-ын мэдээг эмхтгэн бэлтгэж, толилуулах нь олон улсын орны хувьд санхүүгийн тайланг бэлтгэгчдийн болон аудиторуудын ажлын ачааллыг мэдэгдэхүйц нэмэгдүүлж, санхүүгийн тайлангийн нарийн төвөгтэй байдлыг нэмэгдүүлж болох юм. Санхүүгийн тайлагналын статистикийн сууриудад нийцсэн ЗГҮС-ын тодруулгад үндэслэсэн буюу түүнийг агуулсан санхүүгийн тайланг одоо бэлтгэдэггүй улс орнуудын хувьд ялангуяа ийм тохиолдол гардаг. Түүнчлэн, зарим улс оронд, хэрэглэгчид нь ЗГҮС-ын талаархи мэдээллийн хувьд санхүүгийн тайлангаас хараат бус байж болох юм. Ийм улс оронд, ЗГҮС-ын талаархи тодруулгыг санхүүгийн тайлангийн нэгэн хэсэг байдлаар бэлтгэж, толилуулах өртөг зардал нь түүний өгөөжөөс илүү байж болно. Иймд, энэ Стандарт нь ЗГҮС-ын талаархи мэдээллийг тодруулахыг зөвшөөрдөг боловч заавал шаарддаггүй. Улс орон бүрийн засгийн газар буюу зохих эрх бүхий бусад байгууллага нь ЗГҮС-ын талаархи мэдээллийн тодруулгыг санхүүгийн тайланд хийх эсэхийг шийдвэрлэдэг.
13. ЗГҮС-ын талаархи тодруулгыг санхүүгийн тайланд хийдэг тохиолдолд энэ Стандартад заасан шаардлагуудын дагуу уг тодруулгыг хийхийг энэ Стандартаар шаардсан байдаг. Энэ нь ЗГҮС-ын зохих толилуулгыг санхүүгийн тайланд хийсэн бөгөөд ЗГҮС-ын талаархи уг тодруулга нь хамааралтай байх, үнэн зөв илэрхийлэх, ойлгомжтой байх, цаг хугацаандаа байх, зэрэгцүүлэгдэх боломжтой байх, шалгах боломжтой байх гэсэн санхүүгийн мэдээллийн чанарын шинжүүдийг хангаж буй эсэхийг ханган магадалдаг.
14. УСНББОУС-ыг ерөнхийдөө улсын секторын бүх байгууллагад мөрдөнө. Харин засгийн газрын хяналтанд буй бие даасан байгууллагуудын хувьд биш, харин засгийн газрын хувьд ЗГҮС-ын ач холбогдолтой төлөөллийг

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНДСЭН СЕКТОРЫН ТАЛААРХИ  
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОДРУУЛГА

зөвхөн тодруулж болох юм. Иймээс УСНББОУС-уудад дурдсан, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу нэгтгэсэн санхүүгийн тайлангаа бэлтгэдэг засгийн газруудын хувьд мөрдөх шаардлагуудыг энэ Стандартад тусгайлан заасан байдаг. Эдгээр засгийн газарт үндэсний, мужийн/бүсийн болон орон нутгийн засгийн газар хамарч болох юм.

## Тодорхойлолт

15. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

**Засгийн газрын үндсэн сектор** нь санхүүгийн тайлагналын статистикийн сууриудад тодорхойлсон, төв засгийн газрын бүтэц зохион байгуулалтанд хамаарах бүх байгууллагуудаас бүрдэнэ.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д дахин нийтэлсэн болно.

## Улсын Үйлдвэрийн Газар

16. [Хассан]

## Засгийн газрын үндсэн сектор

17. Санхүүгийн тайлагналын статистикийн сууриудын дагуу улсын сектор нь ЗГҮС, улсын санхүүгийн корпорацийн (УСК) сектор, улсын санхүүгийн бус корпорацийн сектор (УСБКС)-оос бүрддэг. Эдгээр секторуудын хүрээн дэх нэмэлт дэд бүлгүүдийг статистик шинжилгээний зорилгоор тодорхойлж болно.
18. УТС 93-т (ба түүний нэмэлт өөрчлөлтөнд) ЗГҮС-ыг дараах зүйлсээс бүрдэнэ гэж тодорхойлсон: (а) төв, мужийн болон орон нутгийн засгийн газрын байнгын оршин суугч бүх нэгжүүд, (б) засгийн газрын түвшин бүр дэх нийгмийн хамгааллын сангууд, ба (в) засгийн газрын нэгжүүдийн хяналтанд буй зах зээлийн бус бөгөөд ашгийн төлөө бус институтууд. Санхүүгийн тайлагналын статистикийн сууриудын дагуу ЗГҮС нь засгийн газрын төвлөрсөн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг бөгөөд засгийн газар болон засгийн газрын байгууллагуудаас үндсэндээ санхүүжүүлэх үйл ажиллагааг эрхлэн явуулдаг зах зээлийн бус, ашгийн төлөө бус бүх байгууллагуудыг ихэвчлэн өөртөө агуулсан байдаг. Иймээс эдгээр байгууллагууд нь засгийн газрын татварын орлого, засгийн газрын корпорациудын ногдол ашиг болон бусад орлогын төсвийн хуваарилалт буюу хуваарилалт, түүнчлэн засгийн газрын зээлээр үндсэндээ санхүүждэг. ЗГҮС нь засгийн газрын хэлтэс газар, шүүх, улсын боловсролын институтууд, улсын эрүүл мэндийн байгууллагууд болон засгийн газрын бусад агентлагууд гэх мэт байгууллагуудыг ихэвчлэн өөртөө агуулдаг. ЗГҮС-т УСК, УСБК хамаарахгүй. УСНББОУС ба санхүүгийн тайлагналын статистикийн сууриудын хоорондох уялдаа

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНДСЭН СЕКТОРЫН ТАЛААРХИ  
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОДРУУЛГА

холбоог бэхжүүлэх нь санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ач холбогдолтой бөгөөд хамааралтай гэж үздэг улс орнуудын хувьд ЗГҮС-ын талаархи мэдээллийн тодруулгыг хийнэ. Иймээс ЗГҮС-ыг тодруулах сонголт хийсэн засгийн газар нь тухайн санхүүгийн тайланд тусгасан ЗГҮС-ын талаархи мэдээлэл нь санхүүгийн тайлагналын статистикийн сууриудын хувьд тэдгээр улс оронд мөрддөг ЗГҮС-ын талаархи тодорхойлолт болон түүний аливаа тайлбаруудтай нийцсэн гэдгийг ханган магадлах шаардлагатай юм.

*Улсын санхүүгийн корпорацийн сектор*

19. УСК-ийн сектор нь засгийн газрын хяналтанд буй байнгын оршин суугч санхүүгийн корпорациуд, бүрэн бус корпорациуд, ашгийн төлөө бус институтуудээс бүрддэг бөгөөд тэдгээр нь тухайн зах зээлд санхүүгийн зуучлалын болон санхүүгийн үйлчилгээг ихэвчлэн эрхлэн явуулдаг. Энэ секторт засгийн газрын хяналтанд буй банкууд, үүн дотроо төв банк, түүнчлэн зах зээлийн сууриар үйл ажиллагаагаа явуулдаг засгийн газрын бусад санхүүгийн институтууд хамаардаг.

*Улсын санхүүгийн бус корпорацийн сектор*

20. УСБК-ийн сектор нь засгийн газрын хяналтанд буй байнгын оршин суугч санхүүгийн бус корпорациуд, бүрэн бус корпорациуд, ашгийн төлөө бус институтуудээс бүрддэг бөгөөд тэдгээр нь тухайн зах зээлд бараа буюу санхүүгийн бус үйлчилгээг нийлүүлдэг. Энэ секторт төрийн өмчит нийтийн аж ахуйн байгууллагууд, түүнчлэн бараа, үйлчилгээг арилждаг бусад байгууллагууд хамаардаг.
21. Санхүүгийн тайлагналын статистикийн сууриуд нь дараах байдлаар тодорхойлдог:
- (а) Корпораци гэдэг нь зах зээлд зориулан бараа, үйлчилгээг нийлүүлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд юм;
  - (б) Бүрэн бус корпораци гэдэг нь үүсгэн байгуулагдаагүй буюу бусад хэлбэрээр хууль ёсоор зохион байгуулагдаагүй боловч корпорацитай адил чиг үүрэг гүйцэтгэдэг байгууллага юм; ба
  - (в) Ашгийн төлөө бус институт гэдэг нь бараа, үйлчилгээг үйлдвэрлэж, нийлүүлдэг боловч түүнийг хянадаг байгууллагадаа зориулан санхүүгийн олз ашиг бий болгодоггүй хуулийн этгээд буюу бусад байгууллага юм.
22. Улсын секторын худалдаа арилжааны байгууллагууд нь санхүүгийн тайлагналын статистикийн сууриудад тодорхойлсон, улсын корпораци буюу улсын бүрэн бус корпорацитай ижил төсөөтэй шинж чанаруудтай байдаг. Гэвч улсын секторын худалдаа арилжааны байгууллагууд болон УСК-ийн сектор, УСБК-ийн секторыг адилтган авч үзэж болохгүй юм. Тухайлбал; байнгын оршин суугч бус, улсын секторын худалдаа арилжааны байгууллагыг УСК эсвэл УСБК гэж ангилж болохгүй.

## Нягтлан бодох бүртгэлийн бодлого

23. **24 ба 25-р параграф**аар шаардсанаас бусад тохиолдолд ЗГҮС-ын талаархи санхүүгийн мэдээллийг тухайн засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэж, толилуулахад мөрддөг нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу тодруулна.
24. ЗГҮС-ын талаархи санхүүгийн мэдээллийг толилуулахдаа байгууллага нь УСК-ийн болон УСБК-ийн секторууд дахь байгууллагуудын хувьд УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*-гийн шаардлагуудыг мөрдөхгүй.
25. ЗГҮС нь УСК болон УСБК-ийн секторууд дахь өөрийн хөрөнгө оруулалтыг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд тэрхүү хөрөнгийг уг санхүүжигчийн цэвэр хөрөнгийн дансны үнээр тайлагнана.
26. ЗГҮС-ын талаархи мэдээллийг тодруулах сонголт хийсэн засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланг салган задлах, ингэснээр ЗГҮС-ыг уг засгийн газрын тайлагнагч байгууллагын нэг сектор байдлаар толилуулна гэсэн үзэл баримтлалыг энэхүү Стандартад тусгадаг. Ийм үзэл баримтлалд нийцүүлэн энэхүү Стандарт нь нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх үедээ мөрдсөн тухайн нэг тодорхойлолт, түүнчлэн хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, толилуулгын шаардлагуудыг нэг гажих нөхцлөөс бусад тохиолдолд уг ЗГҮС-ын тодруулгад мөн адил мөрдөхийг шаарддаг. УСК-ийн болон УСБК-ийн секторууд дахь байгууллагуудтай тухайн ЗГҮС-ын холбогдох харилцааны хувьд УСНББОУС 35-ын шаардлагуудыг мөрдөхгүй байх нь нэг гажих нөхцөл юм.
27. УСНББОУС 35 нь хяналтанд буй байгууллагуудыг мөр мөрөөр нэгтгэснээр санхүүгийн тайлангаа бэлтгэхийг тухайн хяналт тавигч байгууллагуудаас шаарддаг. УСНББОУС 35 нь мөн дараах зүйлсийг агуулдаг: (а) улсын секторт мөрддөг хяналтын үзэл баримтлалын талаархи дэлгэрэнгүй хэлэлцүүлэг, ба (б) санхүүгийн тайлагналын зорилгоор хяналт оршин буй эсэхийг тодорхойлох талаархи заавар удирдамж. Санхүүгийн тайлагналын статистикийн сууриудад тодорхойсончлон, засгийн газрын хяналтанд буй байгууллагууд болох УСК-ийн болон УСБК-ийн сектор дахь байгууллагуудыг УСНББОУС 35-ын шаардлагуудын дагуу уг засгийн газрын санхүүгийн тайланд нэгтгэнэ.
28. Санхүүгийн тайлагналын статистикийн сууриудын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайлан нь бүхэлдээ улсын секторт, түүнчлэн ҮТС 93-ын (ба түүний нэмэлт өөрчлөлтийн) хүрээнд үндэсний эдийн засагт уг ЗГҮС-ын үзүүлэх үр нөлөөг харуулдаг. Ийм чиглэлд үндэслэн санхүүгийн тайлагналын статистикийн сууриуд нь тухайн секторт үл хамаарах улсын секторын байгууллагуудыг бусад секторт оруулсан хөрөнгө оруулалт байдлаар уг ЗГҮС-ын санхүүгийн тайланд толилуулахыг шаарддаг. Мөн түүнчлэн, бусад секторын байгууллагуудтай тухайн ЗГҮС-ын хийсэн ажил гүйлгээг санхүүгийн тайлагналын статистикийн сууриудын дагуу тэрхүү



ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНДСЭН СЕКТОРЫН ТАЛААРХИ  
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОДРУУЛГА

засгийн газрын үйл ажиллагааны тайлан буюу адилтган тайлангаасн хасахгүй.

29. ЗГҮС-т хийх нэгтгэлийн хувьд УСНББОУС 35-ын шаардлагуудыг мөрдөх нь тэрхүү ЗГҮС-ын санхүүгийн тайланг биш, харин засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланг дахин толилуулахад хүргэдэг.
30. Иймээс ЗГҮС-ын талаархи санхүүгийн мэдээллийг тодруулахдаа тэрхүү ЗГҮС-ын хүрээн дэх байгууллагуудын хоорондох үлдэгдэл ба ажил гүйлгээг УСНББОУС 35-ын дагуу устгаж цэвэрлэнэ. Харин ЗГҮСын байгууллагууд болон бусад секторын байгууллагуудын хоорондох үлдэгдэл ба ажил гүйлгээг устгаж цэвэрлэхгүй.
31. Энэ Стандарт нь УСК-ийн буюу УСБК-ийн секторуудын байгууллагууд дахь өөрийн хөрөнгө оруулалтыг тэдгээр байгууллагуудын цэвэр хөрөнгийн дансны үнээр хүлээн зөвшөөрөхийг ЗГҮС-оос шаарддаг. Энэ нь засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланд толилуулсан, түүний нэг хэсэг болох санхүүгийн мэдээллийн задаргааг уг ЗГҮС-ын тодруулгад тусгасан эсэхийг ханган магадалдаг. ЗГҮС нь засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн задаргаа болох тул тэдгээр байгууллагуудын цэвэр хөрөнгийг засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрдөгтэй ижил арга маягаар тэрхүү цэвэр хөрөнгийн өөрчлөлтүүдийг хүлээн зөвшөөрнө.
32. Тайлагналын статистикийн сууриуд нь бүх хөрөнгө, өр төлбөрийг (зээлээс бусад) тухайн тайлант үеийн эцэс бүрд зах зээлийн үнэ цэнээр дахин үнэлэхийг шаарддаг. УСНББОУС-ууд нь хэмжилтийн янз бүрийн шаардлагуудыг тусган агуулдаг бөгөөд хөрөнгө, өр төлбөрийн зарим ангиудын хувьд өртөг болон одоогийн үнэ цэнийг ашиглахыг шаарддаг буюу зөвшөөрдөг. УСНББОУС-ууд нь бүх хөрөнгө, өр төлбөрийг зах зээлийн үнэ цэнээр дахин үнэлэхийг шаарддаггүй. Иймээс ЗГҮС-ын талаархи санхүүгийн тайлангийн тодруулга дахь хөрөнгө, өр төлбөрийн хэмжилт, үүн дотроо УСК-ийн болон УСБК-ийн секторууд дахь хөрөнгө оруулалтын хэмжилт нь тайлагналын статистикийн сууриудад мөрдсөн хэмжилтийн сууриас өөр байж болох юм.

### **Дэлгэрэнгүй задаргаа**

33. Зарим улс оронд, үндэсний засгийн газар нь бүсийн ба/буюу орон нутгийн засгийн газруудыг хянадаг бөгөөд иймээс үндэсний засгийн газрын санхүүгийн тайланд засгийн газрын янз бүрийн түвшинг нэгтгэдэг. Хэрэв санхүүгийн тайлан нь засгийн газрын янз бүрийн түвшинг нэгтгэдэг бол засгийн газрын түвшин тус бүрийн ЗГҮС-ын талаархи мэдээллийг тусад нь тодруулах энэ Стандартын шаардлагуудын дагуу тухайн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн дэлгэрэнгүй задаргааг хийж болно.
34. Ийм дэлгэрэнгүй задаргааг энэ Стандартаар шаарддаггүй. Гэвч санхүүгийн тайланд нэгтгэсэн засгийн газрын түвшин тус бүр дэх ЗГҮС-ын үйл ажиллагаануудын хоорондох харилцан хамаарал, түүнчлэн тухайн улс орны санхүүгийн тайлан болон санхүүгийн тайлагналын статистикийн

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНДСЭН СЕКТОРЫН ТАЛААРХИ  
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОДРУУЛГА

сууриудын хоорондох уялдаа холбоог илүү сайн ойлгоход хэрэглэгчдэд цаашид туслахын тулд ийм дэлгэрэнгүй задаргааг толилуулж болох юм.

## Тодруулга

35. **ЗГҮС-ын талаар хийх тодруулгад хамгийн наад зах нь дараах зүйлс хамаарна:**
- (а) Гол ангиар харуулсан хөрөнгүүд, үүнд бусад секторт хийсэн хөрөнгө оруулалтыг тусад нь харуулна;
  - (б) Гол ангиар харуулсан өр төлбөр;
  - (в) Цэвэр хөрөнгө/өмч;
  - (г) Дахин үнэлгээний нийт нэмэгдэлт ба бууралт, түүнчлэн цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн орлого, зардлын бусад зүйлс;
  - (д) Гол ангиар харуулсан орлого;
  - (е) Гол ангиар харуулсан зардал;
  - (ж) Ашиг, алдагдал;
  - (и) Гол ангиар харуулсан үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ;
  - (к) Хөрөнгө оруулалтын ажиллагааны мөнгөн гүйлгээ; ба
  - (л) Санхүүгийн ажиллагааны мөнгөн гүйлгээ.
- ЗГҮС-ын тодруулгыг толилуулах арга маяг нь УСНББОУС-уудын дагуу бэлтгэсэн засгийн газрын санхүүгийн тайлангаас илүү давуутай байхгүй.**
36. УСНББОУС 1-д заасанчлан, иж бүрэн санхүүгийн тайлан (аккруэл сууриар бэлтгэсэн) нь санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн бодлого болон санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрддэг.
37. Энэ Стандарт нь санхүүгийн тайланд тусгасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардал, мөнгөн гүйлгээний гол ангиудыг тодруулахыг шаарддаг. ЗГҮС-ын тодруулгыг хийх арга маягийг энэ Стандартад тусгайлан заагаагүй. Энэ Стандартын дагуу ЗГҮС-ыг тодруулахаар сонголт хийсэн засгийн газар нь ийм тодруулгыг дараах арга замаар хийж болно. Үүнд: (а) тодруулга тэмдэглэлээр, (б) үндсэн санхүүгийн тайланд нэмэлт багана оруулах байдлаар, эсвэл (в) тухайн улс орны хувьд тохиромжтой гэж үзсэн бусад хэлбэрээр. Гэвч ЗГҮС-ын тодруулгыг толилуулах арга маяг нь УСНББОУС-уудын дагуу бэлтгэсэн, нэгтгэсэн санхүүгийн тайлангаас илүү давуутай байхгүй.
38. ЗГҮС-ын хувьд толилуулсан санхүүгийн мэдээлэл ба засгийн газрын үйл ажиллагааны хоорондох уялдаа холбоог ойлгоход хэрэглэгчдэд туслахын

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНДСЭН СЕКТОРЫН ТАЛААРХИ  
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОДРУУЛГА

тулд санхүүгийн тайлагналын статистикийн сууриуд нь зардлын эдийн засгийн шинж чанар эсвэл Засгийн Газрын Чиг Үүргийн Ангилал (ЗГЧҮА)-д үндэслэсэн ангиудаар уг засгийн газрын нийт зардлыг салган задлах буюу тодруулахыг шаарддаг. ЗГҮС-ын талаархи мэдээллийг тодруулж буй байгууллагууд нь уг ЗГҮС-ын мэдээллийг эдийн засгийн шинж чанараар эсвэл ЗГЧҮА-д нийцсэн ангиллын дагуу салган задалж толилуулахыг энэ Стандартаар шаарддаг ч үгүй, хориглодог ч үгүй. Зарим улс оронд, ЗГҮС-ын тодруулгын хувьд баримталсан ЗГЧҮА-ын ангиллууд нь УСНББОУС 18-ын дагуу мөрдсөн ангиллуудтай ижил төсөөтэй байж болох юм.

39. Байгууллага нь уг толилуулсан мэдээллийн мөн чанарыг ойлгоход хэрэглэгчдэд шаардлагатай аливаа нэмэлт тодруулгыг бас хийнэ.
40. **ЗГҮС-ын тодруулгыг бэлтгэж буй байгууллагууд нь уг ЗГҮС-т тусган оруулсан, түүний хяналтанд буй томоохон байгууллагууд ба өмнөх тайлант үеэс хойш тэдгээр байгууллагуудад орсон аливаа өөрчлөлтүүд, түүнчлэн тэрхүү ЗГҮС-т өмнө нь хамаарч байсан ийм аливаа байгууллагууд цаашид яагаад үүнд хамаарахгүй болсон учир шалтгааны талаархи тайлбарын хамт тодруулна.**
41. ЗГҮС-ын талаархи мэдээллийг тодруулах сонголт хийсэн байгууллагууд нь уг ЗГҮС-т тусган оруулсан, хяналтанд буй томоохон байгууллагуудын жагсаалтыг тодруулахыг энэ Стандартаар шаарддаг. Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэдэг байгууллагууд нь уг нэгтгэсэн санхүүгийн тайланд тусган оруулсан, хяналтанд буй томоохон байгууллагуудын жагсаалтыг тодруулахыг УСНББОУС 35-аар шаарддаг. УСНББОУС 35-ын дагуу санхүүгийн тайланд нэгтгэгддэг бөгөөд ЗГҮС-т хамруулан оруулдаг байгууллагуудын тодруулга нь уг засгийн газрын болон түүний ЗГҮС-ын талаархи мэдээллүүдийн хоорондох уялдаа холбоог ойлгох, түүнчлэн тэрхүү ЗГҮС-ын өөрийнх нь тухай мэдээллийг илүү сайн ойлгоход хэрэглэгчдэд тусалдаг.
42. Үүнтэй адилаар, ЗГҮС-т тусган оруулсан, хяналтанд буй байгууллагуудын өөрчлөлтийн талаархи тодруулга нь уг нэгтгэсэн санхүүгийн тайлан ба ЗГҮС-ын мэдээллийн хоорондох уялдаа холбоог цаг хугацааны явцад хянан үнэлэх боломжийг хэрэглэгчдэд олгодог.

#### **Нэгтгэсэн санхүүгийн тайлантай хийх тохируулга**

43. **ЗГҮС-ын тодруулгыг уг засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлантай тулган тохируулах бөгөөд тэдгээр санхүүгийн тайлан дахь адилтгах зүйл тус бүрийн хувьд хийсэн тохируулгын дүнг тусад нь харуулна.**
44. ЗГҮС-ын хувьд тодруулсан дүнг уг засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн адилтгах дүнтэй тулган тохируулахыг энэ Стандартаар шаарддаг. Байгууллага нь 23-р параграфын дагуу тодорхойлсон УСК-ийн болон УСБК-ийн секторууд дахь хөрөнгө оруулалтын дүнд хийсэн тохируулга ба 35-р параграфын дагуу тусад нь тодруулсан зүйлс нэг бүрд хийсэн тохируулгыг тусад нь толилуулна. Түүнчлэн, байгууллагууд нь

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНДСЭН СЕКТОРЫН ТАЛААРХИ  
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОДРУУЛГА

УСК-ийн болон УСБК-ийн секторуудад хамааруулж болох зүйл нэг бүрд хийх тохируулгын дүнг тусад нь тодруулж болох боловч тэднээс заавал шаарддаггүй. ЗГҮС-т хамаарах зүйл нэг бүрийн дүн ба засгийн газарт хамаарах тухайн зүйлийн нийт дүн хоорондох уялдаа холбоог харуулснаар ийм тохируулга нь өөрийн хариуцлагатай байдлын үүргийг илүү сайн биелүүлэх боломжийг засгийн газарт олгоно.

### **Санхүүгийн тайлагналын статистикийн сууриудтай хийх тохируулга**

45. Санхүүгийн тайлагналын статистикийн сууриуд ба УСНББОУС-ууд нь тухайн тодорхой ажил гүйлгээ болон үйл явдлуудыг бүртгэх өөрсдийн арга хандлагын хувьд ижил төсөөтэй олон талуудтай байдаг. Гэвч ялгаатай талууд бас байдаг. Жишээлбэл; дээрх 32-р параграфт дурдсан, хөрөнгө, өр төлбөрийн хэмжилтийн сууриудын ялгаатай байдлаас гадна санхүүгийн тайлагналын статистикийн сууриуд нь ногдол ашгийг зардал гэж үздэг бол УСНББОУС-ууд нь ногдол ашгийг хуваарилалт гэж үздэг. Мөн санхүүгийн тайлагналын статистик сууриуд нь тухайн нэгтгэсэн санхүүгийн тайланд одоогоор тусгаагүй байгаа санхүүгийн мэдээллийг толилуулах зорилгоор ажил гүйлгээ болон эдийн засгийн бусад гүйлгээг өөр хооронд нь ялган авч үздэг бөгөөд олгох/авах цэвэр зээл, мөнгөн ашиг/алдагдал гэх мэт төсвийн бодлогын шинжилгээнд хамааралтай тодорхой арга хэмжээг голчлон анхаардаг.
46. Нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ЗГҮС-ын тодруулгыг санхүүгийн тайлагналын статистикийн сууриудын дагуу хийх ЗГҮС-ын тодруулгатай тулган тохируулахыг энэхүү Стандартаар шаарддаггүй. Яагаад гэвэл, ийм шаардлагыг бүх улс оронд хэрэгжүүлэх практик боломжит байдал болон өртөг, өгөөжийн харьцааны хувьд эргэлзээтэй байдаг. Гэвч тэмдэглэл тодруулга байдлаар ийм тохируулгыг тусган оруулахыг хориглодоггүй.

### **Хүчин төгөлдөр болох хугацаа**

47. Байгууллага нь энэхүү Стандартыг 2008 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2008 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 47А. 2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-ийн үр дүнд 48-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед УСНББОУС 33-ыг мөрдсөн бол уг нэмэлт өөрчлөлтийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНДСЭН СЕКТОРЫН ТАЛААРХИ  
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОДРУУЛГА

- 47Б. 2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*-гийн үр дүнд 24, 26, 27, 29, 30, 41-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь УСНББОУС 35-ыг мөрдсөн үеэс эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг дагаж мөрдөнө.
- 47В. 2016 оны 4 дүгээр сард гаргасан УСНББОУС 2015-ын *Сайжруулалтууд*-аар 13-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 47Г. 2016 оны 4 дүгээр сард гаргасан УСНББОУС-ын *Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 16-р параграфыг хасаж, 3, 22-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
48. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

## Дүгнэлтийн Үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 22-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### Оршил

- ДҮ1. *Үндэсний Тооцооны Систем 1993 (ҮТС 93) (ба түүний нэмэлт өөрчлөлт), Засгийн Газрын Санхүүгийн Статистикийн Гарын Авлага 2001 (ЗГССГА), Европын Тооцооны Систем 1995 (ЕТС 95) нь бүгд засгийн газрын үндсэн сектор (ЗГҮС)-ын талаархи санхүүгийн мэдээллийг хэвлэн нийтлэхийг засгийн газруудаас шаарддаг. Статистикийн зорилгын хувьд, ЗГҮС нь үндсэндээ зах зээлийн бус үйл ажиллагааг эрхэлдэг, засгийн газрын хяналтанд буй байгууллагуудаас бүрддэг. Өөрийн үндсэн үйл ажиллагаа байдлаар засгийн газрын гол чиг үүргийг гүйцэтгэдэг тийм байгууллагуудаас бүрдэнэ гэж ЗГҮС-ыг зарим үед тодорхойлдог. Хэдийгээр улсын корпорациудын бүх өмчийг засгийн газар буюу түүний байгууллагууд эзэмшдэг боловч ийм улсын корпорациудыг ЗГҮС-т хамруулдаггүй.*
- ДҮ2. *Одоо мөрдөж буй УСНББОУС-ууд нь ЗГҮС-ын талаархи мэдээллийг санхүүгийн тайландаа тодруулахыг байгууллагуудаас шаарддаггүй. УСНББОУС-ууд нь тухайн тайлагнагч байгууллагын хяналтанд буй бүх нөөцүүдийн талаархи мэдээллийг агуулсан санхүүгийн тайлан бэлтгэхийг байгууллагуудаас шаарддаг бөгөөд тэдгээр хяналтанд буй бүх байгууллагуудыг нэгтгэх дүрэм журмыг тодорхойлдог. УСНББОУС 18, *Сегментийн Тайлагнал* нь сегментүүдийг тодорхойлох ба тэдгээр сегментүүдийн талаархи мэдээллийг толилуулахыг байгууллагуудаас бас шаарддаг.*
- ДҮ3. *Зарим улс орны засгийн газар нь санхүүгийн тайлан, түүнчлэн санхүүгийн тайлагналын статистикийн сууриудын дагуу бэлтгэсэн, улсын секторын санхүүгийн шинж чанартай болон гүйцэтгэл, үр дүнгийн талаархи мэдээллийн аль алиныг бэлтгэж, толилуулах ба олон нийтэд зориулан хэвлэдэг.*
- ДҮ4. *УСНББОУС3 нь тохиромжтой тохиолдолд УСНББОУС-ыг тайлагналын статистикийн сууриудтай нийцүүлэхийг дэмждэг. Ингэж нийцүүлэх арга хэрэгсэл болгон УСНББОУС3 нь ЗГҮС-ын талаархи мэдээллийг толилуулахад чиглэгдсэн УСНББОУС-ыг засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нэг хэсэг байдлаар хөгжүүлэн боловсруулахыг статистикийн хамтын нийгэмлэг дэмждэг.*
- ДҮ5. *Ялангуяа үндэсний буюу бусад засгийн газар нь (а) УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайлан, ба (б) санхүүгийн тайлагналын статистикийн сууриудад нийцсэн санхүүгийн мэдээллийн аль алиныг хэвлэн нийтэлдэг тийм улс орнуудын хувьд ЗГҮС-ын талаархи мэдээллийн тодруулга нь санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийг ач холбогдолтой мэдээллээр хангаж чадах юм. Мөн УСНББОУС3 нь ийм мэдээллийг тодруулснаар тухайн*

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНДСЭН СЕКТОРЫН ТАЛААРХИ  
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОДРУУЛГА

засгийн газрын зах зээлийн болон зах зээлийн бус үйл ажиллагааны хоорондох уялдаа холбоог илүү сайн ойлгоход хэрэглэгчдэд туслалцаа үзүүлж чадна гэсэн үзэл бодолтой байдаг. Гэвч санхүүгийн тайлагналын статистикийн сууриудын дагуу бэлтгэх санхүүгийн тайланг тогтмол бэлтгэж, олон нийтэд нээлттэй танилцуулдаггүй улс орнуудын хувьд ийм тодруулгыг хийсний үр өгөөж нь тэдгээрийг бэлтгэх өртөг зардлаас мэдэгдэхүйц их байна гэдэгт УСНББОУСЗ итгэдэггүй. Иймээс эдгээр тодруулгыг заавал шаарддаггүй.

ДҮ6. Энэ Стандарт нь зөвхөн засгийн газруудад мөрдөх шаардлагуудыг тодорхойлдог. Яагаад гэвэл, ЗГҮС-ын ач холбогдолтой төлөөллийг зөвхөн нийт засгийн газрын хувьд тодруулах боломжтой байдаг. Зарим улс орны хувьд, үндэсний засгийн газар нь бүсийн ба/буюу орон нутгийн засгийн газруудыг хянадаг байж болох юм. Ийм тохиолдолд засгийн газрын түвшин бүрийн хувьд ЗГҮС-ын талаархи мэдээллийг тусад нь тодруулахын тулд тухайн санхүүгийн тайланг нэмж задалж болно. Ийм тодруулга нь засгийн газрын түвшин нэг бүр дэх ЗГҮС-ын үйл ажиллагаануудын хоорондох уялдаа холбоог илүү сайн ойлгоход хэрэглэгчдэд туслах магадлалтай байдаг. Гэвч зарим улс оронд ийм тодруулга нь нягтлан бодох бүртгэлийн системд, түүнчлэн мэдээг цуглуулж, нэгтгэн бэлтгэх хариуцлага бүхий хүмүүст нэмэлт ачаалал үүсгэх бөгөөд санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд ийм тодруулгын үзүүлэх үр өгөөж нь түүний өртгөөс илүү гарах эсэх нь тодорхойгүй байж болох юм. Иймээс ЗГҮС-ын талаархи мэдээллийг тодруулах сонголт хийсэн байгууллагууд нь тухайн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн засгийн газрын түвшин нэг бүрийн ЗГҮС-ын талаархи мэдээллийг мөн тусад нь тодруулахыг энэ Стандартаар шаарддаггүй. Гэхдээ ийм тодруулга хийхийг хориглодоггүй.

### Нэгтгэл ба задаргаа

ДҮ7. Санхүүгийн тайлагналын статистикийн сууриуд ба УСНББОУС-ууд нь тухайн тодорхой ажил гүйлгээ болон үйл явдлуудыг бүртгэх өөрсдийн арга хандлагын хувьд ижил төсөөтэй олон талуудтай байдаг. Гэвч ялгаатай талууд бас байдаг. Жишээлбэл; санхүүгийн тайлагналын статистикийн сууриуд нь:

- (а) бүх хөрөнгө, өр төлбөрийг (зээлээс бусад) тухайн тайлант үеийн эцэс бүрд зах зээлийн үнэ цэнээр дахин үнэлэхийг шаарддаг. УСНББОУС-ууд нь хэмжилтийн янз бүрийн шаардлагуудыг тусган агуулдаг бөгөөд хөрөнгө, өр төлбөрийн зарим ангиудын хувьд өртөг болон одоогийн үнэ цэнийг ашиглахыг шаарддаг буюу зөвшөөрдөг.
- (б) ногдол ашгийг зардал гэж үздэг бол УСНББОУС-ууд нь ногдол ашгийг хуваарилалт гэж үздэг;
- (в) санхүүгийн мэдээллийг толилуулах зорилгоор ажил гүйлгээ болон эдийн засгийн бусад гүйлгээг өөр хооронд нь ялган авч үздэг. УСНББОУС нь одоогоор үүнтэй адилтгах ялган тодорхойлолтыг хийдэггүй; ба

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНДСЭН СЕКТОРЫН ТАЛААРХИ  
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОДРУУЛГА

(г) ЗГҮС-ын талаархи санхүүгийн мэдээллийн толилуулгад голлон чиглэдэг бөгөөд улсын секторын бусад секторуудыг тусдаа бүрэлдэхүүн хэсэг гэж үздэг, энэ утгаараа макро-эдийн засгийн нийт үзүүлэлтийн тууштай байдлыг хангахын тулд эдийн засгийн бусад үлдсэн хэсгүүдийн толилуулгад мөрддөгтэй ижил хүлээн зөвшөөрөлтийн болон хэмжилтийн дүрмүүдийг баримталдаг. Санхүүгийн тайлагналын статистикийн сууриудын дагуу ЗГҮС-ын хувьд бэлтгэдэг санхүүгийн тайлан нь бараа, үйлчилгээг арилждаг бөгөөд засгийн газрын хяналтанд буй байгууллагууд болох УСБК-ууд болон банк гэх мэт УСК-уудыг нэгтгэн тусгадаггүй. Харин УСНББОУС нь тухайн байгууллагын хяналтанд буй бүх хөрөнгө, өр төлбөр, орлого, зардал, мөнгөн гүйлгээний талаархи санхүүгийн мэдээллийг толилуулдаг нэгтгэсэн санхүүгийн тайланд голчлон чиглэдэг.

ДҮ8. ЗГҮС-ын талаархи мэдээллийн тодруулга нь засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн задаргаа байхыг энэ Стандартаар шаарддаг. Энэ нь УСНББОУС 18-ын дагуу сегментийн мэдээллийн тодруулгад баримталдагтай ижил хандлага юм. Иймээс нэг гажих нөхцлөөс бусад тохиолдолд, нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрддөг нягтлан бодох бүртгэлийн бодлоготой ижил нягтлан бодох бүртгэлийн бодлогыг ЗГҮС-ын тодруулга хийхдээ мөрдөнө.

ДҮ9. ЗГҮС-ын талаархи тодруулгыг тухайн санхүүгийн тайланд хийдэг тохиолдолд УСНББОУС 35-ын шаардлагуудыг УСК болон УСБК-д мөрдөхгүй. Яагаад гэвэл, УСК-ийн болон УСБК-ийн секторуудад УСНББОУС 35-ыг мөрдөх нь уг ЗГҮС-ын санхүүгийн тайланг биш, харин засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланг дахин толилуулахад хүргэх юм. Энэ нь ЗГҮС-ын мэдээллийн тодруулгыг УСНББОУС-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайлан ба санхүүгийн тайлагналын статистикийн сууриудын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайлангийн хоорондох гүүр болгох зорилгыг алдагдуулах юм.

### **Сегментийн тайлагнал**

ДҮ10. Өөрийн зорилтуудад хүрэхдээ тухайн байгууллагын хийсэн гүйцэтгэлийн үнэлгээний болон шийдвэр гаргалтын зорилгоор мэдэгдэхүйц үйл ажиллагаа буюу үйл ажиллагаануудын бүлгийн талаархи зарим мэдээллийн хувьд тусдаа тодруулга хийхийг УСНББОУС 18-аар шаарддаг. УСНББОУС 18 нь арилжааны ба арилжааны бус ажил гүйлгээ, үйл явдлууд эсвэл засгийн газрын зах зээлийн ба зах зээлийн бус үйл ажиллагаануудыг өөр хооронд нь ялган авч үздэггүй. Харин энэ Стандарт нь гол үйлчилгээ буюу үйлчилгээнүүдийн бүлгийг засгийн газрын ЗГҮС эсвэл УСК-ууд болон УСБК-ууд нийлүүлж буй эсэхээс үл хамааран тэдгээрийн нийлүүлэлттэй холбоотой орлого, зардал, хөрөнгө, өр төлбөрийн тодруулгыг голчлон анхаардаг. ЗГҮС-ын талаархи мэдээллийн тодруулгаар уг сегментийн тайлагналын зорилтуудад хүрч чадахгүй. Иймээс ЗГҮС-ын талаархи мэдээллийг тодруулах сонголт хийсэн засгийн газар нь сегментүүдийн талаархи мэдээллийг бас тодруулах шаардлагатай байдаг.



ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНДСЭН СЕКТОРЫН ТАЛААРХИ  
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОДРУУЛГА

ДҮ11. Санхүүгийн тайлагналын статистикийн сууриуд нь эдийн засгийн шинж чанараар эсвэл ЗГЧҮА-аар ангилсан уг засгийн газрын зардлууд буюу зарлагын талаархи мэдээллийг толилуулдаг. ЗГҮС-ын талаархи нэмэлт мэдээллийг тодруулахын тулд эдгээр ангиллын сууриудын аль нэгийг ашиглаж болох юм. Зарим тохиолдолд, засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланд сегментийн мэдээллийг тодруулахын тулд ЗГЧҮА-ыг баримталж болох юм.

### Тохируулга

ДҮ12. Энэ Стандартын шаардлагуудын дагуу ЗГҮС-ын талаар тодруулсан мэдээлэл нь санхүүгийн тайлагналын статистикийн сууриудын дагуу толилуулсан мэдээллээс агуулга ба хэлбэрийн хувьд өөр байж болно.

ДҮ13. Энэ Стандартын дагуу ЗГҮС-ын талаархи мэдээллийг тодруулах сонголт хийсэн засгийн газар нь дараах зүйлсийн хоорондох тохируулгыг бэлтгэн тодруулах шаардлагатай эсэхийг УСНББОУСЗ авч үзсэн: (а) санхүүгийн тайлан дахь ЗГҮС-ын тодруулга, ба (б) санхүүгийн тайлагналын статистикийн сууриудын дагуу хийсэн ЗГҮС-ын тодруулга. Зарим улс орны хувьд ийм шаардлага нь санхүүгийн тайлан бэлтгэгч нар мэдэгдэхүйц өртөг зардал гаргахад хүргэх бөгөөд тэдгээр өртөг зардал нь өгөөжөөс илүү байж болох юм гэж УСНББОУСЗ санаа зовж байсан. Ингэснээр энэ нь засгийн газрууд уг тодруулгыг бэлтгэхээс өөр бусад сонголт хийхэд хүргэж болох юм. Энэ талаар УСНББОУСЗ-ийн тусгайлан санаа зовдог асуудлын жишээнд дараах зүйлс хамаарна:

- (а) Санхүүгийн тайлан болон статистикийн мэдээллийг эмхтгэн бэлтгэх цаг хугацаа нь тухайн санхүүгийн тайланг хууль тогтоомжийн шаардлагууд ба/буюу УСНББОУС-ын шаардлагуудын дагуу аудит хийлгэж, гарын үсэг зуран баталгаажуулах буюу нийтэд гаргахыг зөвшөөрөхөд шаардлагатай тогтоосон хугацааны дотор уг тохируулгыг бэлтгэж дуусгах тийм боломжтой байгаа эсэх;
- (б) Ийм шаардлагыг тусган оруулах нь уг тохируулгын аудитыг хүндрэлтэй болгох ба тухайн статистикийн тайлангийн аудитыг мөн төвөгтэй болгох эсэх; ба
- (в) Байгууллага нь санхүүгийн тайлагналын статистикийн сууриудын шаардлагуудын дагуу хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг дахин хэмжиж, дахин ангилах шаардлагатай байж болох ба энэ нь уг ЗГҮС-ын мэдээллийн тодруулгын ач холбогдлыг бууруулах эсэх.

ДҮ14. Тэнцвэртэй байдлыг хангах үүднээс УСНББОУСЗ нь энэ үе шатанд ийм тохируулгыг шаардах хэрэггүй гэж дүгнэсэн. Гэхдээ, энэ Стандартын шаардлагуудын дагуу толилуулсан ЗГҮС-ын тодруулгыг УСНББОУС-ын шаардлагуудын дагуу бэлтгэсэн засгийн газрын санхүүгийн тайлан дахь адилтгах зүйлстэй тохируулах ийм тохируулга нь (а) сайжруулсан ил тод, ойлгомжтой байдалтай нийцсэн, (б) алдаагүй, (в) хэрэглэгчдэд ач холбогдолтой байвал зохино. Энэ Стандартын шаардлагуудын дагуу толилуулсан ЗГҮС-ын тодруулгын тохируулга ба санхүүгийн тайлагналын

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНДСЭН СЕКТОРЫН ТАЛААРХИ  
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОДРУУЛГА

статистикийн сууриудын дагуу толилуулсан ЗГҮС-ын тодруулгын хоорондох уг тохируулгад тодруулга хийхийг хориглодоггүй.

**2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУСЗ-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 22-д хийсэн хянан засварлалт**

ДҮ15. УСНББОУСЗ нь 2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (a) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р* параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

## **Хэрэгжүүлэх заавар удирдамж**

*Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 22-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### **Үлгэрчилсэн санхүүгийн тайлангийн бүтэц**

#### **“А” засгийн газар – Санхүүгийн тайлангийн хэсгээс**

##### **Санхүүгийн тайлангийн тодруулгаас авсан ишлэл**

Тэмдэглэл: Засгийн газрын үндсэн сектор (ЗГҮС)-ын тодруулга

Засгийн газрын үндсэн сектор (ЗГҮС)-ын хувьд дараах тодруулгыг хийсэн. Нэгтгэлийн шаардлагууд нь улсын санхүүгийн корпораци (УСК)-ийн сектор ба улсын санхүүгийн бус корпораци (УСБК)-ийн секторын хувьд өөр байхаас бусад тохиолдолд энэхүү тодруулга нь нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдсөн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тусгасан. УСНББОУС 22, *Засгийн Газрын Үндсэн Секторын Талаархи Санхүүгийн Мэдээллийн Тодруулга*-ын шаардлагуудын дагуу УСК болон УСБК-ийг уг ЗГҮС-ын тодруулгад нэгтгэн оруулдаггүй боловч тэдгээрийг ЗГҮС-ын хөрөнгө оруулалт байдлаар хүлээн зөвшөөрдөг. УСК ба УСБК-д оруулсан хөрөнгө оруулалтыг тухайн санхүүжигчийн цэвэр хөрөнгийн дансны үнээр хэмжиж, тайлангийн нэг мөрийн зүйл байдлаар толилуулдаг.

ЗГҮС нь төв засгийн газрын бүх яамдууд, түүнчлэн уг засгийн газрын хяналтанд байдаг бөгөөд үндсэндээ зах зээлийн бус үйл ажиллагаа эрхэлдэг бусад байгууллагуудаас бүрддэг. Эдгээр байгууллагад дараах байгууллагууд хамаарна:

“Я” яам

“Ю” яам

“Э” яам

Өмнө нь харилцаа холбооны яам хариуцдаг байсан шуудангийн үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагааг арилжааны сууриар эрхлэн явуулахаар тухайн тайлант үед өөрчлөлт оруулсан бөгөөд уг ЗГҮС-ын хувьд толилуулсан санхүүгийн мэдээлэлд цаашид тусган оруулахааргүй болсон.

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНДСЭН СЕКТОРЫН ТАЛААРХИ  
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОДРУУЛГА

**ЗГҮС-ын Санхүүгийн байдлын тайлан – 20Х2 оны 12-р сарын 31–ний өдөр**

(мянгачилсан дүнгээр)

	ЗГҮС		УСК ба УСБК		Устгалт		Нийт ЗГ	
	20Х2	20Х1	20Х2	20Х1	20Х2	20Х1	20Х2	20Х1
<b>ХӨРӨНГӨ</b>								
<b>Эргэлтийн хөрөнгө</b>								
Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө	X	X	X	X	(X)	(X)	X	X
Авлага	X	X	X	X	(X)	(X)	X	X
Бараа материал	X	X	X	X			X	X
Урьдчилж төлсөн төлбөр	X	X	X	X	(X)	(X)	X	X
Хөрөнгө оруулалт	X	X	X	X			X	X
Бусад эргэлтийн хөрөнгө	X	X	X	X			X	X
	X	X	X	X	(X)	(X)	X	X
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>								
Авлага	X	X	X	X	(X)	(X)	X	X
Хөрөнгө оруулалт	X	X	X	X			X	X
Бусад сектор дахь хөрөнгө оруулалт	X	X			(X)	(X)		
Бусад санхүүгийн хөрөнгө	X	X	X	X	(X)	(X)	X	X
Дэд бүтэц ба үндсэн хөрөнгө	X	X	X	X			X	X
Газар ба барилга	X	X	X	X			X	X
Биет бус хөрөнгө	X	X	X	X			X	X
Бусад санхүүгийн бус хөрөнгө	X	X	X	X			X	X
	X	X	X	X	(X)	(X)	X	X
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>X</b>	<b>X</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>								
<b>Богино хугацаат өр төлбөр</b>								
Өглөг	X	X	X	X	(X)	(X)	X	X
Богино хугацаат зээл	X	X	X	X			X	X
Урт хугацаат зээлийн тайлант үед төлөх хэсэг	X	X	X	X			X	X
Нөөц сан	X	X	X	X			X	X
Ажилтны тэтгэмж	X	X	X	X			X	X
Бусад богино хугацаат өр төлбөр	X	X	X	X	(X)	(X)	X	X
	X	X	X	X	(X)	(X)	X	X

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНДСЭН СЕКТОРЫН ТАЛААРХИ  
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОДРУУЛГА

	ЗГҮС		УСК ба УСБК		Устгалт		Нийт ЗГ	
	20X2	20X1	20X2	20X1	20X2	20X1	20X2	20X1
<b>Урт хугацаат өр төлбөр</b>								
Өглөг	X	X	X	X	(X)	(X)	X	X
Зээл	X	X	X	X			X	X
Нөөц сан	X	X	X	X			X	X
Ажилтны тэтгэмж	X	X	X	X			X	X
Бусад өр төлбөр	X	X	X	X	(X)	(X)	X	X
	X	X	X	X	(X)	(X)	X	X
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>X</b>	<b>X</b>
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ</b>	X	X	X	X	(X)	(X)	X	X
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧ</b>								
Нөөц сан	X	X	X	X	(X)	(X)	X	X
Хуримтлагдсан ашиг/(алдагдал)	X	X	X	X	(X)	(X)	X	X
	X	X	X	X	(X)	(X)	X	X
<b>НИЙТ ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧ</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>X</b>	<b>X</b>

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНДСЭН СЕКТОРЫН ТАЛААРХИ  
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОДРУУЛГА

**ЗГҮС-ын 20Х2 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жилийн Санхүүгийн үр дүнгийн тайлан – Засгийн газрын чиг үүргийн ангилал**

(мянгачилсан дүнгээр)

	ЗГҮС		УСК ба УСБК		Устгалт		Нийт ЗГ	
	20Х2	20Х1	20Х2	20Х1	20Х2	20Х1	20Х2	20Х1
<b>Орлого</b>								
Татвар	X	X			(X)	(X)	X	X
Хураамж, төлбөр, торгууль	X	X	X	X	(X)	(X)	X	X
Бусад сектороос авсан орлого	X	X	X	X	(X)	(X)		
Бусад засгийн газраас авсан шилжүүлэг	X	X	X	X			X	X
Үйл ажиллагааны бусад орлого	X	X	X	X	(X)	(X)	X	X
<b>Нийт орлого</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>X</b>	<b>X</b>
<b>Зардал</b>								
Нийтийн ерөнхий үйлчилгээ	X	X					X	X
Батлан хамгаалах Нийгмийн хэв журам ба аюулгүй байдал	X	X	X	X			X	X
Эдийн засгийн асуудлууд	X	X					X	X
Байгаль орчны хамгаалал	X	X	X	X	(X)	(X)	X	X
Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ	X	X	X	X	(X)	(X)	X	X
Эрүүл мэнд	X	X	X	X			X	X
Амралт сувилгаа, соёл, шашин	X	X					X	X
Боловсрол	X	X	X	X	(X)	(X)	X	X
Нийгмийн хамгаалал	X	X	X	X	(X)	(X)	X	X
<b>Нийт зардал</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>X</b>	<b>X</b>
<b>Тайлант үеийн ашиг/(алдагдал)</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>X</b>	<b>X</b>

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНДСЭН СЕКТОРЫН ТАЛААРХИ  
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОДРУУЛГА

**ЗГҮС-ын 20X2 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жилийн Санхүүгийн үр дүнгийн тайлан – Зардлын эдийн засгийн ангилал**

**(Толилуулгын өөр хувилбар арга)**

(мянгачилсан дүнгээр)

	ЗГҮС		УСК ба УСБК		Устгалт		Нийт ЗГ	
	20X2	20X1	20X2	20X1	20X2	20X1	20X2	20X1
<b>Орлого</b>								
Татвар	X	X			(X)	(X)	X	X
Хураамж, төлбөр, торгууль	X	X	X	X	(X)	(X)	X	X
Бусад сектороос авсан орлого	X	X	X	X	(X)	(X)		
Бусад засгийн газраас авсан шилжүүлэг	X	X	X	X			X	X
Үйл ажиллагааны бусад орлого	X	X	X	X	(X)	(X)	X	X
<b>Нийт орлого</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>X</b>	<b>X</b>
<b>Зардал</b>								
Ажилтны цалин хөлс	X	X	X	X	(X)	(X)	X	X
Бараа, үйлчилгээний ашиглалт	X	X	X	X	(X)	(X)	X	X
Үндсэн хөрөнгийн зарцуулалт	X	X	X	X	(X)	(X)	X	X
Хүү	X	X	X	X	(X)	(X)	X	X
Татаас	X	X	X	X	(X)	(X)	X	X
Нийгмийн халамж	X	X	X	X	(X)	(X)	X	X
Бусад зардал	X	X	X	X			X	X
<b>Нийт зардал</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>X</b>	<b>X</b>
<b>Тайлант үеийн ашиг/(алдагдал)</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>X</b>	<b>X</b>

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНДСЭН СЕКТОРЫН ТАЛААРХИ  
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОДРУУЛГА

**ЗГҮС-ын 20X2 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жилийн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**  
(мянгачилсан дүнгээр)

	ЗГҮС			УСК ба УСБК	Устгалт	Нийт ЗГ
	Дахин үнэл- гээний нөөц	Хөрвүүлэл- тийн нөөц	Хуримтлагдсан ашиг/(алдагдал)			
20X0 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	X	(X)	X	X	X	X
Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	X		X	X		X
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний бууралт	(X)		(X)	(X)	X	(X)
Валютын хөрвүүлэлтийн ханшийн зөрүү		(X)	(X)	(X)		(X)
Санхүүгийн үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрөөгүй цэвэр олз, гарз	X	(X)		X	(X)	X
Тайлант үеийн цэвэр ашиг			X	X	(X)	X
20X1 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	X	(X)	X	X	(X)	X
Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	(X)			(X)	X	(X)
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний нэмэгдэл	X			X	(X)	X
Валютын хөрвүүлэлтийн ханшийн зөрүү		(X)		X		X
Санхүүгийн үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрөөгүй цэвэр олз, гарз	(X)	(X)		(X)	(X)	(X)
Тайлант үеийн цэвэр алдагдал			(X)	(X)	(X)	(X)
20X2 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	X	(X)	X	X	(X)	X



ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНДСЭН СЕКТОРЫН ТАЛААРХИ  
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОДРУУЛГА

**ЗГҮС-ын 20Х2 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жилийн Мөнгөн гүйлгээний тайлан**

(мянгачилсан дүнгээр)

	ЗГҮС		УСК ба УСБК		Устгалт		Нийт ЗГ	
	20Х2	20Х1	20Х2	20Х1	20Х2	20Х1	20Х2	20Х1
<b>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>								
<b>Мөнгөн орлого</b>								
Татвар	X	X			(X)	(X)	X	X
Бараа, үйлчилгээний борлуулалт			X	X	(X)	(X)	X	X
Татаас			X	X	(X)	(X)	X	X
Хүлээн авсан хүү			X	X			X	X
Бусад секторуудаас засгийн газрын авсан ногдол ашиг	X	X			(X)	(X)		
Бусад мөнгөн орлого	X	X	X	X	(X)	(X)	X	X
<b>Мөнгөн зарлага</b>								
Ажилтны зардал	(X)	(X)	(X)	(X)			(X)	(X)
Тэтгэвэр тэтгэмж	(X)	(X)	(X)	(X)			(X)	(X)
Бэлтгэн	(X)	(X)	(X)	(X)			(X)	(X)
нийлүүлэгчдэд төлсөн								
Төлсөн хүү	(X)	(X)	(X)	(X)			(X)	(X)
Бусад секторт төлсөн ногдол ашиг			(X)	(X)	X	X	(X)	(X)
Бусад мөнгөн зарлага	(X)	(X)	(X)	(X)	X	X	(X)	(X)
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>X</b>	<b>X</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>								
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	(X)	(X)	(X)	(X)			(X)	(X)
Үндсэн хөрөнгийн борлуулалтын мөнгөн орлого	X	X	X	X			X	X
Хөрөнгө оруулалтын борлуулалтын мөнгөн орлого	X	X	X	X			X	X
Гадаад валютаарх үнэт цаасны худалдан авалт	(X)	(X)	(X)	(X)			(X)	(X)
<b>Хөрөнгө оруулалтын ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНДСЭН СЕКТОРЫН ТАЛААРХИ  
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОДРУУЛГА

	ЗГҮС		УСК ба УСБК		Устгалт		Нийт ЗГ	
	20X2	20X1	20X2	20X1	20X2	20X1	20X2	20X1
<b>САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>								
Авсан зээл	X	X	X	X			X	X
Зээлийн буцаан төлөлт	(X)	(X)	(X)	(X)			(X)	(X)
<b>Санхүүгийн ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>X</b>	<b>X</b>
<i>Мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/(бууралт)</i>	X	X	X	X	(X)	(X)	X	X
<i>Тайлант үеийн эхэн дэх мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл</i>	X	X	X	X	(X)	(X)	X	X
<b>Тайлант үеийн эцэс дэх мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>

## **УСНББОУС 23–АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО (ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)**

### **УСНББОУС-ЫН ТҮҮХ**

Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

УСНББОУС 23, Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Татвар ба Шилжүүлэг)-ыг 2006 оны 12 дугаар сард гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 23-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл (2017 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2011-ийн Сайжруулалтууд (2011 оны 10 дугаар сард гаргасан)
- УСНББОУС 28, Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга (2010 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба Хэмжилт (2010 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 31, Биет Бус Хөрөнгө (2010 оны 01 дүгээр сард гаргасан)

### **УСНББОУС 23-ын нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт**

<b>Өөрчлөгдсөн параграф</b>	<b>Хэрхэн өөрчилсөн</b>	<b>Юугаар өөрчилсөн</b>
Танилцуулга хэсэг	Хассан	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
1	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
2	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
3	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
4	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
5	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 29, 2010 оны 01-р сар

6	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
10	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 29, 2010 оны 01-р сар
31	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
37	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 28, 2010 оны 01-р сар
87	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 29, 2010 оны 01-р сар
105А	Шинэ	УСНББОУС 29, 2010 оны 01-р сар
105Б	Шинэ	УСНББОУС 29, 2010 оны 01-р сар
106	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 29, 2010 оны 01-р сар
116	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
117	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
118	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
119	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
120	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
121	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
122	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
123	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
124А	Шинэ	УСНББОУС 28, 2010 оны 01-р сар
124Б	Шинэ	УСНББОУС 29, 2010 оны 01-р сар
124В	Шинэ	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
124Г	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
124Д	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
125	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
ХЗУ27	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 31, 2010 оны 01-р сар
ХЗУ54	Шинэ	УСНББОУС 29, 2010 оны 01-р сар

2006 оны 12 дугаар сар

**УСНББОУС 23–АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)**

**АГУУЛГА**

	Параграф
Зорилго	1
Цар хүрээ	2-6
Тодорхойлолт	7-28
Арилжааны бус ажил гүйлгээ	8-11
Орлого	12-13
Болзол	14-16
Шилжүүлсэн хөрөнгийн нөхцөл	17-18
Шилжүүлсэн хөрөнгөнд тавигдах хязгаарлалт	19
Хэлбэрээс илүү мөн чанар	20-25
Татвар	26-28
Арилжааны бус ажил гүйлгээнээс үүсэх нөөцийн анхны орлогын гүйлгээний шинжилгээ	29
Хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт	30-43
Хөрөнгийн хяналт	32-33
Өнгөрсөн үйл явдал	34
Нөөцийн магадлалт орлогын гүйлгээ	35
Болзошгүй хөрөнгө	36
Эздийн хувь оролцоо	37-38
Ажил гүйлгээний арилжааны болон арилжааны бус бүрэлдэхүүн хэсгүүд	39-41
Хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үеийн хэмжилт	42-43
Арилжааны бус ажил гүйлгээний орлогын хүлээн зөвшөөрөлт	44-47
Арилжааны бус ажил гүйлгээний орлогын хэмжилт	48-49
Өр төлбөр гэж хүлээн зөвшөөрсөн одоогийн үүрэг	50-58
Одоогийн үүрэг	51-54
Шилжүүлсэн хөрөнгийн нөхцөл	55-56
Өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөх үеийн хэмжилт	57-58
Татвар	59-75
Татвар ногдох үйл явдал	65
Татварын урьдчилж орсон орлого	66
Татвар ногдох ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгийн хэмжилт	67-70
Татварын системээр дамжуулан төлсөн зардал ба татварын зарлага	71-75
Шилжүүлэг	76-105Б
Шилжүүлсэн хөрөнгийн хэмжилт	83
Өрөөс чөлөөлөх ба өр төлбөрийг хариуцах	84-87
Торгууль	88-89
Өвлүүлсэн хөрөнгө	90-92
Бэлэг, хандив, үүн дотроо хариу төлбөргүй бараа	93-97

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

Хариу төлбөргүй үйлчилгээ	98-103
Амлалт	104
Шилжүүлгийн урьдчилж орсон орлого	105
Хөнгөлөлттэй зээл	105А-105Б
Тодруулга	106-115
Шилжилтийн нөхцөл	116-123
Хүчин төгөлдөр болох хугацаа	124-125
Дүгнэлтийн үндэслэл	
Хэрэгжүүлэх заавар удирдамж	

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 23, *Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Татвар ба Шилжүүлэг)*-ыг 1-125-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 23-ыг түүний зорилгын агуулга, Дүгнэлтийн Үндэслэл, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

1. Энэ Стандартын зорилго нь улсын секторын нэгдэлд хүргэдэг арилжааны бус ажил гүйлгээнээс бусад, арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн орлогын санхүүгийн тайлагналын шаардлагуудыг тодорхойлоход оршино. Энэ Стандарт нь арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн орлогыг хүлээн зөвшөөрөх ба хэмжихдээ харгалзан үзэх шаардлагатай асуудлууд, үүн дотроо эздийн хувь оролцооны тодорхойлолтыг авч үзнэ.

## Цар хүрээ

2. **Нягтлан бодох бүртгэлийн аккрузл суурийн дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн орлогыг тайлагнахдаа энэхүү Стандартыг мөрдөнө. Арилжааны бус ажил гүйлгээ болох улсын секторын нэгдэлд энэ Стандартыг мөрдөхгүй.**
3. [Хассан]
4. [Хассан]
5. Энэ Стандарт нь арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн орлогыг авч үздэг. Арилжааны ажил гүйлгээнээс үүссэн орлогыг УСНББОУС 9, *Арилжааны Ажил Гүйлгээний Орлого*-д авч үзсэн. Улсын секторын байгууллагуудын хүлээн авсан орлого нь арилжааны ба арилжааны бус ажил гүйлгээний аль алианаас үүсдэг бол засгийн газрын болон бусад улсын секторын байгууллагуудын орлогын ихэнх хэсэг нь үндсэндээ дараах гэх мэт арилжааны бус ажил гүйлгээнээс бий болдог:
  - (а) Татвар; ба
  - (б) Шилжүүлэг (мөнгөн эсвэл мөнгөн бус гэдгээс үл хамаарна), үүн дотроо, буцалтгүй тусламж, өрөөс чөлөөлөлт, торгууль, өвлүүлсэн хөрөнгө, бэлэг, хандив, хариу төлбөргүй бараа ба үйлчилгээ, хүлээн авсан хөнгөлөлттэй зээлийн зах зээлийн түвшинд хамаарахгүй хэсэг.
6. Засгийн газар нь улсын секторын зарим байгууллагуудыг хооронд нь нэгтгэх, ба зарим байгууллагуудыг хоёр буюу хэд хэдэн тусдаа байгууллагуудад хуваах замаар улсын секторт дахин зохион байгуулалт хийж болно. Тайлагнагч нэг байгууллага үүсгэн бий болгохын тулд хоёр буюу хэд хэдэн үйл ажиллагааг нэгтгэн нийлүүлэх үед улсын секторын нэгдэл үүсдэг. Ийм бүтцийн өөрчлөлт нь нэг байгууллага өөр нэг үйл ажиллагаа эсвэл байгууллагыг худалдан авахтай ихэвчлэн холбоогүй байдаг боловч шинэ эсвэл одоо оршин буй байгууллага нь өөр нэг үйл ажиллагааны эсвэл байгууллагын бүх хөрөнгө, өр төлбөрийг олж эзэмшихэд бүтцийн өөрчлөлт хийгдэж болох юм. Улсын секторын нэгдлийг УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийн дагуу тайлагнана.



## Тодорхойлолт

7. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

Шилжүүлсэн хөрөнгийн нөхцөл гэдэг нь тухайн хөрөнгөнд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг шилжүүлэн авагч нь тусгайлан заасны дагуу зарцуулах шаардлагатай, эсвэл уг ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг тэрхүү шилжүүлэгчид буцаан өгөх ёстой гэж тусгайлан заасан болзол юм.

Байгууллага нь өөрийн зорилтуудыг хэрэгжүүлэхдээ тухайн хөрөнгийг ашиглах буюу өөр бусад байдлаар түүнээс өгөөж хүртэж чаддаг ба тэрхүү өгөөжийг бусад этгээд хүртэхийг хязгаарлах буюу бусад байдлаар зохицуулдаг тохиолдолд хөрөнгийн хяналт үүсдэг.

Татварын системээр дамжуулан төлсөн зардал гэдэг нь үр шим хүртэгч нь татвар төлсөн эсэхээс үл хамааран түүнд олгогдох дүн юм.

Торгууль гэдэг нь хууль буюу зохицуулалтыг зөрчсөний үр дагавар болгон шүүх эсвэл хуулийг хэрэгжүүлэгч бусад этгээдийн тодорхойлсны дагуу улсын секторын байгууллагууд хүлээн авсан эсвэл хүлээн авахаар болсон эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи юм.

Шилжүүлсэн хөрөнгөнд тавигдах хязгаарлалт гэдэг нь тухайн шилжүүлсэн хөрөнгийг ашиглаж болох зорилгыг хязгаарлах буюу чиглүүлэх боловч хэрэв тусгайлан заасны дагуу ашиглаагүй бол тэрхүү ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг тухайн шилжүүлэгчид буцаан өгөх шаардлагатай гэж тусгайлан заадаггүй болзлууд юм.

Шилжүүлсэн хөрөнгийн болзол гэдэг нь тухайн тайлагнагч байгууллагын хувьд гаднын этгээд болох байгууллагууд уг шилжүүлсэн хөрөнгийг ашиглах талаар хууль, тогтоомж буюу заавал биелүүлэх хэлцэлд заасан нөхцлүүд юм.

Татварын зарлага гэдэг нь бусад этгээдэд олдох боломжгүй хөнгөлөлтийг зарим татвар төлөгчдөд олгодог татварын хуулийн хөнгөлөлттэй нөхцлүүд юм.

Татвар ногдох үйл явдал гэдэг нь засгийн газар, хууль тогтоогч байгууллага буюу бусад эрх бүхий байгууллагуудаас татвар ногдох зүйл гэж тодорхойлсон үйл явдал юм.

Татвар гэдэг нь засгийн газарт орлого оруулахын тулд тогтоосон бөгөөд хууль тогтоомжийн дагуу улсын секторын байгууллагуудад албан журмаар төлсөн эсвэл төлөх эдийн засгийн үр өгөөж буюу

**үйлчилгээний чадавхи юм. Хууль зөрчсөний улмаас ногдуулж буй торгууль буюу бусад шийтгэвэр нь татварт хамаарахгүй.**

**Шилжүүлэг гэдэг нь татвараас бусад, арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн орлогын гүйлгээ юм.**

**Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь-д* дахин нийтэлсэн болно.**

### **Арилжааны бус ажил гүйлгээ**

8. Зарим ажил гүйлгээний хувьд энэ нь ойролцоогоор тэнцүү үнэ цэнэтэй арилжаа гэдэг нь ойлгомжтой тодорхой байдаг. Эдгээр нь арилжааны ажил гүйлгээ бөгөөд бусад УСНББОУС-д авч үздэг.
9. Харин өөр зарим ажил гүйлгээний хувьд, байгууллага нь үнэ төлбөргүйгээр эсвэл нэрлэсэн төлбөрийг хариуд нь шууд төлснөөр нөөцийг хүлээн авдаг. Эдгээр нь мэдээж арилжааны бус ажил гүйлгээ бөгөөд энэхүү Стандартад авч үзнэ. Жишээлбэл; татварын хуулиар татвар төлөхийг албан журмаар тогтоодог учраас татвар төлөгч нь татварыг төлдөг. Татвар ногдуулж буй Засгийн газар нь татвар төлөгчдөд төрийн янз бүрийн үйлчилгээ үзүүлдэг боловч үүнийг татварын төлбөрийн хариу болгон үзүүлдэггүй.
10. Байгууллага нь хүлээн авсан нөөцийнхөө хариуд зарим төлбөрийг шууд төлж болох боловч тэрхүү төлбөр нь уг хүлээн авсан нөөцийн бодит үнэ цэнэтэй ойролцоо биш байх тохиолдолд арилжааны бус ажил гүйлгээний өөр бүлэг болох юм. Ийм тохиолдолд байгууллага нь арилжааны ба арилжааны бус ажил гүйлгээнүүдийн хослол байгаа эсэхийг тодорхойлох бөгөөд түүний бүрэлдэхүүн нэг бүрийг тусад нь хүлээн зөвшөөрнө. Жишээлбэл; байгууллага нь олон талт хөгжлийн агентлагаас 6 сая ТН-ийн санхүүжилт хүлээн авсан. Гэрээнд зааснаар, байгууллага нь уг хүлээн авсан санхүүжилтийн 5сая ТН-ийг 10 жилийн туршид 5 хувийн хүүтэйгээр төлөх ёстой бөгөөд энэ үед адилтгах зээлийн хүүний зах зээлийн түвшин нь 11 хувь байсан. Тус байгууллага нь 1 сая ТН-ийн (хүлээн авсан 6 сая ТН-ээс буцаан төлөх 5 сая ТН-ийг хасах) буцалтгүй тусламжийг бодитойгоор хүлээн авсан бөгөөд адилтгах зээлийн зах зээлийн хүүний түвшнээс 6 хувиар бага хүүтэй, 5 сая ТН-ийн хөнгөлөлттэй зээлийн гэрээ байгуулсан. Хүлээн авсан 1 сая ТН-ийн буцалтгүй тусламж, түүнчлэн гэрээний нөхцлийн дагуу төлөх хүүний төлбөрийн зах зээлийн түвшинд хамаарахгүй хэсэг нь арилжааны бус ажил гүйлгээ юм. Гэрээнд заасан үндсэн зээл ба уг зээлийн хугацаанд төлөх хүүний төлбөрүүд нь арилжааны ажил гүйлгээ юм.
11. Арилжааны эсвэл арилжааны бус ажил гүйлгээ эсэх нь шууд тодорхой биш өөр зарим ажил гүйлгээнүүд бас байдаг. Ийм тохиолдолд ажил

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

гүйлгээний мөн чанарыг шалгаснаар арилжааны ажил гүйлгээ эсвэл арилжааны бус ажил гүйлгээ эсэхийг тодорхойлно. Жишээлбэл; бараа борлуулалтыг ихэвчлэн арилжааны ажил гүйлгээ гэж ангилдаг. Гэвч ажил гүйлгээг татаастай үнээр, өөрөөр хэлбэл тэрхүү борлуулсан барааны бодит үнэ цэнэтэй ойролцоогоор тэнцүү биш үнээр хийсэн бол тухайн ажил гүйлгээ нь арилжааны бус ажил гүйлгээний тодорхойлолтонд хамаарна. Ажил гүйлгээний мөн чанар нь арилжааны эсвэл арилжааны бус ажил гүйлгээний шинж чанартай эсэхийг тодорхойлохдоо мэргэжлийн шүүн тунгаалт хийдэг. Мөн түүнчлэн, байгууллага нь худалдааны хөнгөлөлт, тоо хэмжээний хөнгөлөлт авдаг буюу янз бүрийн учир шалтгаанаар тухайн хөрөнгийн жишиг үнээс бусад хасалт хийлгэдэг байж болох юм. Үнийн ийм бууралтууд нь тухайн ажил гүйлгээг заавал арилжааны бус ажил гүйлгээ гэдгийг илэрхийлэхгүй юм.

### **Орлого**

12. Орлого нь уг тайлагнагч байгууллагын хүлээн авсан буюу авах эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн нийт орлогын гүйлгээнээс бүрдэх бөгөөд эздээс оруулсан хувь оролцоотой холбоотойгоос бусад байдлаар цэвэр хөрөнгө/өмчид гарсан өсөлтийг илэрхийлдэг. Засгийн газрын болон засгийн газрын бусад байгууллагын эсвэл бусад гуравдагч этгээдийн агент байдлаар цуглуулан авсан дүн нь тухайн агентын цэвэр хөрөнгийн өсөлт буюу орлого болохгүй. Яагаад гэвэл, тус агент байгууллага нь өөрийн зорилгыг хэрэгжүүлэхдээ тэрхүү цуглуулсан хөрөнгийн ашиглалтыг хянах буюу өөр бусад байдлаар өгөөж хүртэж чадахгүй юм.
13. Байгууллага нь арилжааны бус ажил гүйлгээнээс бий болох орлоготой холбоотойгоор зарим зардал гаргадаг тохиолдолд ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн нийт орлогын гүйлгээ нь орлого болох бөгөөд нөөцийн аливаа зарлагын гүйлгээг уг ажил гүйлгээний өртөг зардал гэж хүлээн зөвшөөрнө. Жишээлбэл; тайлагнагч байгууллага нь өөр байгууллагаас түүнд өгсөн үндсэн хөрөнгийн шилжүүлэгтэй холбоотойгоор хүргэлтийн болон угсарч суурилуулах өртөг зардлыг төлөх шаардлагатай бол тэдгээр өртөг зардлыг уг үндсэн хөрөнгийн шилжүүлгээс үүсэх орлогоос тусад нь хүлээн зөвшөөрнө. Хүргэлтийн болон угсарч суурилуулалтын өртгийг УСНББОУС 17, *Үндсэн Хөрөнгө*-ийн дагуу хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн дүнд тусган оруулна.

### **Болзол**

14. Хөрөнгийг тодорхой арга замаар ашиглана, иймээс тухайн хүлээн авагч байгууллага нь тэрхүү тодорхой арга замаар ажиллах буюу гүйцэтгэнэ гэсэн ойлголт, хүлээлттэйгээр шилжүүлж болох юм. Тухайн шилжүүлсэн хөрөнгийг хүлээн авагч нь ашиглах талаархи нөхцлийг хууль, тогтоомж буюу гаднын талуудтай байгуулсан заавал биелүүлэх хэлцлээр тогтоодог тохиолдолд тэдгээр нөхцөл нь энэ Стандартад заасанчлан болзол болно. Энэ Стандартад тодорхойлсончлон, болзлын гол шинж бол тухайн

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

байгууллага шууд өөрөө эсвэл хяналтандаа буй байгууллагаар дамжуулан болзлыг өөртөө тогтоодоггүй байх явдал юм.

15. Шилжүүлсэн хөрөнгөтэй холбоотой болзол нь нөхцөл эсвэл хязгаарлалтын аль нэг байж болно. Нөхцөл ба хязгаарлалт нь хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед түүнд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг тодорхой зорилгоор ашиглах буюу зарцуулахыг байгууллагаас (гүйцэтгэлийн үүрэг) шаардаж болох бол зөвхөн нөхцөл нь тухайн болзол зөрчигдсэн тохиолдолд уг ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг тэрхүү шилжүүлэгчид буцаан өгөхийг (буцаах үүргийг) шаарддаг.
16. Болзол нь хууль буюу захиргааны арга хэмжээний дагуу хууль ёсны хүчин төгөлдөр байдаг. Хэрэв хууль, тогтоомж буюу бусад заавал биелүүлэх хэлцлийн нөхцөл нь хууль ёсны хүчин төгөлдөр бус бол энэ Стандартад тодорхойлсон болзол болохгүй. Болзлоос гэрээний бус үүрэг үүсэхгүй. УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө* нь гэрээний бус үүргийн хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийн шаардлагуудыг тогтоодог.

#### **Шилжүүлсэн хөрөнгийн нөхцөл**

17. Шилжүүлсэн хөрөнгийн нөхцөл (цаашид “нөхцөл” гэж нэрлэнэ) нь тухайн хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг тусгайлан заасны дагуу ашиглах эсвэл нөхцлийг зөрчсөн тохиолдолд уг ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг тэрхүү шилжүүлэгчид буцаан өгөхийг байгууллагаас шаарддаг. Иймээс хүлээн авагч нь нөхцөлт хөрөнгийн хяналтыг анх олж авах үедээ тэрхүү ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг гуравдагч талд шилжүүлэх одоогийн үүргийг хүлээж байна. Яагаад гэвэл, хүлээн авагч нь уг шилжүүлсэн хөрөнгөнд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг гуравдагч талд тодорхой бараа, үйлчилгээ нийлүүлэхэд зориулан зарцуулах эсвэл уг ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг тэрхүү шилжүүлэгчид буцаан өгөх шаардлагатай тул нөөцийн зарлагын гүйлгээнээс зайлсхийх боломжгүй юм. Иймээс хүлээн авагч нь нөхцөлт хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үедээ өр төлбөрийг бас хүлээн зөвшөөрнө.
18. Удирдан зохицуулахад хялбар байлгах үүднээс, бусад зорилгоор шилжүүлэн авах ёстой бусад хөрөнгөөс тухайн буцаах дүнг хассанаар тэрхүү шилжүүлсэн хөрөнгө болон ирээдүйн эдийн засгийн бусад үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг зохих ёсоор буцааж болох юм. Уг тайлагнагч байгууллага нь нийт дүнг өөрийн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн хэвээр байна. Өөрөөр хэлбэл, байгууллага нь зөрчсөн нөхцлийн дагуу тухайн хөрөнгийн буцаалтын хувьд хөрөнгө ба өр төлбөрийн бууралтыг хүлээн зөвшөөрөх боловч тэрхүү хөрөнгө, өр төлбөрийн ба/буюу орлогын хүлээн зөвшөөрөлтийг шинэ шилжүүлэлтийн хувьд хүлээн зөвшөөрөх юм.

### **Шилжүүлсэн хөрөнгөнд тавигдах хязгаарлалт**

19. Шилжүүлсэн хөрөнгөнд тавигдах хязгаарлалтууд (цаашид “хязгаарлалт” гэнэ) нь хөрөнгийг тусгайлан заасны дагуу ашиглаагүй тохиолдолд уг шилжүүлсэн хөрөнгө буюу ирээдүйн эдийн засгийн бусад үр өгөөж, үйлчилгээний чадавхийг тэрхүү шилжүүлэгчид буцаан өгөх шаардлагыг тусган агуулдаггүй. Иймээс хүлээн авагч нь хязгаарлалттай хөрөнгийн хяналтыг анх олж авах үедээ тэрхүү ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг гуравдагч талд шилжүүлэх одоогийн үүргийг хүлээдэггүй. Хүлээн авагч нь хязгаарлалтыг зөрчсөн тохиолдолд шилжүүлэгч буюу бусад тал нь тухайлбал, асуудлыг шүүх болон маргаан шийдвэрлэх бусад этгээдэд танилцуулах эсвэл засгийн газрын сайд, бусад эрх бүхий албан тушаалтнаар удирдамж чиглэл өгүүлэх гэх мэт захиргааны арга хэмжээ авах буюу өөр бусад байдлаар уг хүлээн авагчид хариуцлага тооцуулах сонголттой байж болох юм. Ийм арга хэмжээ нь тухайн байгууллага хязгаарлалтыг даган биелүүлэхэд хүргэх буюу шүүх, маргаан шийдвэрлэх бусад этгээд болон эрх бүхий байгууллагад дуудагдсанаар иргэний эсвэл эрүүгийн хариуцлага хүлээлгэх үр дүнтэй байж болно. Хөрөнгийг олж эзэмшсэний үр дүнд биш, харин хязгаарлалтыг зөрчсөний улмаас ийм хариуцлага хүлээдэг.

### **Хэлбэрээс илүү мөн чанар**

20. Болзол нь нөхцөл эсвэл хязгаарлалт эсэхийг тодорхойлохдоо уг болзлын зөвхөн хэлбэрийг биш, харин мөн чанарыг харгалзан үзэх шаардлагатай. Тухайлбал; шилжүүлсэн хөрөнгийг гуравдагч талд бараа, үйлчилгээ нийлүүлэхэд ашиглан зарцуулна эсвэл тухайн шилжүүлэгчид буцаан өгөх шаардлагатай гэсэн ганц заалт нь уг хөрөнгийн хяналтыг байгууллага олж авах үед өр төлбөр үүсэх эсэхийг дангаараа тодорхойлоход хангалтгүй байдаг.
21. Болзол нь нөхцөл эсвэл хязгаарлалт эсэхийг тодорхойлохдоо байгууллага нь тухайн хөрөнгө буюу ирээдүйн эдийн засгийн бусад үр өгөөж, үйлчилгээний чадавхийг буцаан өгөх шаардлага нь хууль ёсны хүчин төгөлдөр эсэх, уг шилжүүлэгч нь үүнийг хууль ёсоор хэрэгжүүлэх боломжтой эсэхийг харгалзан үзнэ. Хэрэв шилжүүлэгч нь хөрөнгө буюу ирээдүйн эдийн засгийн бусад үр өгөөж, үйлчилгээний чадавхийг буцаан авах шаардлагыг хууль ёсоор хэрэгжүүлж чадахгүй бол уг болзол нь нөхцлийн тодорхойлолтыг хангахгүй бөгөөд түүнийг хязгаарлалт гэж үзнэ. Зөрчил гарсан тохиолдолд шилжүүлсэн хөрөнгө буюу ирээдүйн эдийн засгийн бусад үр өгөөж, үйлчилгээний чадавхийг буцаан авах шаардлагаа шилжүүлэгч нь хэзээ ч хууль ёсоор хэрэгжүүлж байгаагүй гэдгийг түүний өмнөх туршлага харуулж байвал тэрхүү болзол нь хэлбэрийн хувьд нөхцөл боловч мөн чанарын хувьд нөхцөл биш, иймээс хязгаарлалт болно гэж уг хүлээн авагч байгууллага нь дүгнэж болох юм. Байгууллага нь уг шилжүүлэгчтэй харьцаж байсан өмнөх туршлагагүй эсвэл шилжүүлсэн хөрөнгө буюу ирээдүйн эдийн засгийн бусад үр өгөөж, үйлчилгээний чадавхийг буцаан авах шаардлагаа тэрхүү шилжүүлэгч хууль ёсоор хэрэгжүүлэхэд хүргэхээр болзлыг зөрчиж байгаагүй бөгөөд

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

өөр эсрэг нотолгоо байхгүй тохиолдолд байгууллага нь шилжүүлэгч өөрийн болзлыг хууль ёсоор хэрэгжүүлнэ гэж төсөөлөх хэрэгтэй, иймээс тухайн болзол нь нөхцлийн тодорхойлолтыг хангах юм.

22. Нөхцлийн тодорхойлолт нь хүлээн авагч байгууллагад гүйцэтгэлийн үүрэг хүлээлгэдэг. Өөрөөр хэлбэл, хүлээн авагч нь уг шилжүүлсэн хөрөнгөнд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг тусгайлан заасны дагуу ашиглан зарцуулах эсвэл тухайн хөрөнгө буюу ирээдүйн эдийн засгийн бусад үр өгөөж, үйлчилгээний чадавхийг тэрхүү шилжүүлэгчид буцаан өгөх шаардлагатай байдаг. Нөхцлийн тодорхойлолтыг хангахын тулд гүйцэтгэлийн үүрэг нь зөвхөн хэлбэрээс гадна мөн чанартай байх бөгөөд тухайн нөхцлийн үр дагавар болох шаардлагатай юм. Гүйцэтгэхээс өөр хувилбаргүй үйлдлийг хийж гүйцэтгэхийг байгууллагаас шаардах уг шилжүүлгийн гэрээний заалт нь тэрхүү заалт мөн чанарын хувьд нөхцөл ч биш, хязгаарлалт ч биш гэж тухайн байгууллага дүгнэхэд хүргэж болох юм. Яагаад гэвэл, энэ тохиолдолд уг шилжүүлгийн заалт нь тухайн хүлээн авагч байгууллагад гүйцэтгэлийн үүрэг хүлээлгэдэггүй.
23. Өр төлбөр гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангахын тулд нөөцийн зарлагын гүйлгээ гарах нилээд магадлалтай ба гүйцэтгэлийг тухайн нөхцөлтэй харьцуулах шаардлагатай бөгөөд үнэлэх боломжтой байна. Иймээс нийлүүлэх бараа, үйлчилгээний шинж төрөл буюу тоо хэмжээ, зохих ёсоор олж эзэмших хөрөнгийн шинж төрөл, түүнчлэн хэрэв хамааралтай бол гүйцэтгэлийг хийх хугацаа гэх мэт асуудлуудыг нөхцөлд тусгайлан заах шаардлагатай юм. Мөн түүнчлэн, шилжүүлэгч өөрөө эсвэл түүний нэрийн өмнөөс гүйцэтгэлийг байнга хянан үнэлэх шаардлагатай байдаг. Байгууллага нь нөхцлийн шаардлагуудыг хэсэгчлэн биелүүлвэл тухайн хөрөнгийн адилтгах үнэ цэнэтэй хувь тэнцүүлэн буцаахаар болзолд заадаг бөгөөд буцаах үүргээ илтэд биелүүлэхгүй бол тэрхүү үүргийг өмнө нь албадан хэрэгжүүлж байсан тохиолдолд ийм нөхцөл байдал ихэвчлэн үүсдэг.
24. Зарим тохиолдолд, хөрөнгийг тусгайлан заасан ирээдүйн үйл явдал гарч тохиолдохгүй бол шилжүүлэгчид буцаах болзолтойгоор шилжүүлж болох юм. Жишээлбэл; үндэсний засгийн газар нь адилтгах хувь оролцоог тухайн орон нутгийн засаг захиргааны байгууллага гаргана гэсэн болзолтойгоор түүнд мөнгө санг олгосон тохиолдолд ийм нөхцөл байдал үүсэж болох юм. Энэ тохиолдолд болзлыг зөрчинө гэж хүлээгдэж буй хугацаа хүртэл буцаалтын үүрэг үүсэхгүй бөгөөд түүнийг хүлээн зөвшөөрөх шалгуур хангагдах хүртэл өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй.
25. Гэвч хүлээн авагч нь уг шилжүүлэг урьдчилж орсон орлогын мөн чанартай эсэхийг харгалзан үзэх шаардлагатай. Энэ Стандартад дурдсанаар, урьдчилж орсон орлого нь татвар ногдох үйл явдал гарч тохиолдохоос эсвэл шилжүүлгийн гэрээ нь заавал биелэгдэх гэрээ болохоос өмнө хүлээн авсан нөөцийг илэрхийлнэ. Шилжүүлгийн гэрээ нь заавал биелүүлэх гэрээ хараахан болоогүй байгаа учраас урьдчилж орсон орлого нь хөрөнгө ба одоогийн үүргийн аль алиныг бий болгох үр дүнтэй байдаг.

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

Ийм шилжүүлэг нь арилжааны ажил гүйлгээний шинж төрөлтэй тохиолдолд түүнийг УСНББОУС 9-ийн дагуу авч үзнэ.

**Татвар**

26. Татвар нь засгийн газрууд болон улсын секторын бусад олон байгууллагуудын орлогын гол эх үүсвэр юм. Засгийн газарт орлого оруулахын тулд тогтоосон бөгөөд хууль тогтоомжийн дагуу улсын секторын байгууллагуудад албан журмаар төлсөн эсвэл төлөх эдийн засгийн үр өгөөж гэж татварыг 7-р параграфт тодорхойлсон байдаг. Харин хууль зөрчсөний улмаас ногдуулж буй торгууль буюу бусад шийтгэвэр нь татварт хамаарахгүй. Хандив, үйлчилгээний төлбөр гэх мэт засгийн газарт эсвэл улсын секторын байгууллагуудад албан бус журмаар төлж буй шилжүүлэг нь хэдийгээр арилжааны бус ажил гүйлгээний үр дүн байж болох боловч татвар биш юм. Бүрэн эрхийнхээ хүрээнд засгийн газар нь өөрийн улс орны хэмжээнд татвар төлөгч гэж нэрлэгдэх хувь хүн болон бусад байгууллагуудад татвар ногдуулдаг.
27. Татварын хууль тогтоомж нь улс орон бүрд харилцан адилгүй боловч нийтлэг олон шинж чанаруудтай байдаг. Татварын хууль тогтоомж нь (а) татварыг цуглуулан авах уг засгийн газрын эрхийг тогтоодог, (б) татварыг тооцоолох суурийг тодорхойлдог, (в) татварыг удирдан зохицуулах горимыг, өөрөөр хэлбэл татварын авлагыг тооцоолох ба төлбөрөө хүлээн авсан гэдгийг ханган магадлах горимыг тогтоодог. Татварын хууль тогтоомж нь тухайн татварыг удирдан зохицуулдаг засгийн газрын агентлагт татварын тайланг үечлэн танилцуулахыг татвар төлөгчдөөс шаарддаг. Татвар төлөгч нь татвар ногдох үйл ажиллагааны түвшний талаархи дэлгэрэнгүй мэдээлэл болон нотолгоогоор ерөнхийдөө хангадаг бөгөөд засгийн газар нь татварын авлагын дүнг тооцоолдог. Татварыг хураах арга хэмжээ нь янз бүр байдаг боловч засгийн газар нь хуулийн зарга маргаан үүсгэхгүйгээр төлбөрийг тогтмол хүлээн авдаг гэдгийг ханган магадлахад үндсэндээ чиглэгддэг. Татварын хуулийг ихэвчлэн чанд мөрддөг бөгөөд хуулийг зөрчсөн хувь хүн болон байгууллагад хатуу хариуцлага хүлээлгэдэг.
28. Татвар ногдох үйл явдлаас өмнө хүлээн авсан дүн болох урьдчилж орсон орлого нь татварын хувьд бас үүсэж болох юм.

**Арилжааны бус ажил гүйлгээнээс үүсэх нөөцийн анхны орлогын гүйлгээний шинжилгээ**

29. Хөрөнгийн тодорхойлолтыг хангах ба хүлээн зөвшөөрөх шалгуурыг биелүүлсэн нөөцийн хяналтыг олж авсан үед байгууллага нь арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгийг хүлээн зөвшөөрдөг. Зээлдүүлэгч нь өрөөс чөлөөлөх гэх мэт зарим нөхцөл байдалд өмнө нь хүлээн зөвшөөрсөн өр төлбөрийн дансны үнэд бууралт гарч болох юм. Ийм тохиолдолд хөрөнгийг хүлээн зөвшөөрөхийн оронд байгууллага нь уг өр төлбөрийн дансны үнийг бууруулдаг. Зарим тохиолдолд хөрөнгийн хяналт олж авалт нь тухайн байгууллага өр төлбөр гэж хүлээн зөвшөөрөх үүргийг


АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

мөн өөртөө агуулсан байж болно. Эздээс оруулсан хувь оролцоо нь орлогыг бий болгохгүй, иймээс ажил гүйлгээ нэг бүрийг шинжилж, эздийн аливаа хувь оролцоог тусад нь тайлагнана. Нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн аль элементийг тухайн ажил гүйлгээний үр дүн байдлаар хүлээн зөвшөөрөх эсэхийг тодорхойлохын тулд байгууллага нь энэ Стандартад заасан хандлагын дагуу арилжааны бус ажил гүйлгээг шинжилдэг. Нөөцийн орлогын гүйлгээ байгаа тохиолдолд орлого үүссэн эсэхийг тодорхойлохын тулд байгууллагын гүйцэтгэх шинжилгээний процессыг дараах блок схемд харуулав. Уг блок схемийн бүтцийг энэ Стандартад баримталсан. Ажил гүйлгээг тайлагнах шаардлагуудыг 30-115-р параграфт заасан.



АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

**Нөөцийн анхны орлогын гүйлгээний шинжилгээний үлгэрчилсэн жишээ**



1. Блок схем нь зөвхөн үлгэрчилсэн жишээ бөгөөд Стандартыг орлохгүй. Стандартыг тайлбарлах тусламж болгон үүнийг харуулсан болно.
2. Зээлдүүлэгч нь өрөөс чөлөөлөх гэх мэт зарим тохиолдолд өмнө нь хүлээн зөвшөөрсөн өр төлбөрийн дансны үнэд бууралт гарч болох юм. Энэ тохиолдолд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхийн оронд байгууллага нь уг өр төлбөрийн дансны үнийг бууруулдаг.
3. Байгууллага нь одоогийн бүх үүргийг биелүүлсэн эсэхийг тодорхойлохдоо, нөхцлийн тодорхойлолтыг уг шилжүүлсэн хөрөнгөнд мөрдөлт болон өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх шалгуурыг харгалзан үздэг.

## Хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт

30. Хөрөнгийг УСНББОУС 1-д өнгөрсөн үйл явдлын үр дүнд байгууллага хяналтандаа оруулсан бөгөөд түүнээс уг байгууллагад ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бий болохоор хүлээгдэж буй нөөц гэж тодорхойлсон байдаг.
31. **Хариу төлбөргүй үйлчилгээнээс бусад, арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн ба хөрөнгийн тодорхойлолтыг хангах нөөцийн орлогын гүйлгээг зөвхөн дараах тохиолдолд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө:**
- (а) **Хөрөнгөтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь тухайн байгууллагад орох нилээд магадлалтай байх; ба**
  - (б) **Хөрөнгийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадах.<sup>1</sup>**

## Хөрөнгийн хяналт

32. Хөрөнгийн үр өгөөжид бусад этгээдийг хандан нэвтрүүлэхгүй байх буюу зохицуулах чадвар боломж нь хяналтын чухал элемент бөгөөд энэ нь бүх байгууллагууд хандан нэвтэрч, үр өгөөж хүртдэг нийтийн бараа, бүтээгдэхүүнээс тухайн байгууллагын хөрөнгийг ялган тодорхойлж өгдөг. Улсын секторт засгийн газар нь тодорхой үйл ажиллагаанд жишээлбэл, санхүүгийн институтууд буюу тэтгэврийн сангийн хувьд зохицуулалтын үүргийг гүйцэтгэдэг. Ийм зохицуулалтын үүрэг нь уг зохицуулагдсан зүйлс засгийн газрын хөрөнгийн тодорхойлолтыг хангана эсвэл тэдгээр хөрөнгийг зохицуулж буй засгийн газрын нийтлэг зорилготой санхүүгийн тайланд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангана гэсэн утгыг заавал илэрхийлэх албагүй юм. 98-р параграфын дагуу байгууллага нь хариу төлбөргүй үйлчилгээг хүлээн зөвшөөрч болох боловч заавал хүлээн зөвшөөрөх албагүй юм.
33. Улсын секторын байгууллагад нөөцийг шилжүүлэх санаа төлөвлөгөөний мэдэгдэл нь хүлээн авагч уг нөөцийг хянасан гэж тодорхойлоход дангаараа хангалтгүй байдаг. Жишээлбэл; улсын сургууль нь ойн түймэрт өртсөн бөгөөд засгийн газар нь уг сургуулийг сэргээн босгохын тулд мөнгө санг шилжүүлэх өөрийн санаа төлөвлөгөөг зарлан мэдэгдсэн бол тухайн сургууль нь ийнхүү мэдэгдэл гаргасан өдөр нөөцийн орлогын гүйлгээг (нөөцийн авлага) хүлээн зөвшөөрөхгүй. Нөөцийг шилжүүлэхээс өмнө шилжүүлгийн гэрээг байгуулах шаардлагатай тохиолдолд хүлээн авагч байгууллага нь тэрхүү нөөцөд шилжүүлэгч хандан нэвтрэхийг хязгаарлах буюу зохицуулж чадахгүй учраас уг гэрээ нь заавал биелэгдэх гэрээ болох

---

<sup>1</sup> Найдвартай мэдээлэл нь материаллаг алдаа ба туйлшралаас ангид байх бөгөөд өөрийн илэрхийлэхээр зориулагдсан буюу илэрхийлнэ гэж ул үндэслэлтэйгээр хүлээж болох зүйлсийг үнэн зөв илэрхийлэхдээ хэрэглэгчдээс хамаардаг байж болох юм. Найдвартай байдлын тайлбарын талаархи шилжилтийн арга хандлагыг УСНББОУС 1-ийн ДҮ16-р параграфт авч хэлэлцсэн.

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

хүртэл нөөцийг хяналтандаа авсан гэж тодорхойлохгүй. Ихэнх тохиолдолд, байгууллага нь хөрөнгийг хүлээн зөвшөөрөхөөс өмнө тэрхүү нөөц дэх өөрийн хяналтын хууль ёсны хүчин төгөлдөр байдлыг тогтоох шаардлагатай байдаг. Хэрэв байгууллага нь нөөцийн хувьд хууль ёсны хүчин төгөлдөр шаардах эрхгүй бол тэрхүү нөөцөд шилжүүлэгч хандан нэвтрэхийг хязгаарлах буюу зохицуулж чадахгүй юм.

### **Өнгөрсөн үйл явдал**

34. Улсын секторын байгууллагууд нь хөрөнгийг ихэвчлэн засгийн газар болон бусад байгууллагуудаас, үүн дотроо татвар төлөгчдөөс авах, эсвэл тэрхүү хөрөнгийг худалдан авах буюу үйлдвэрлэх замаар олж эзэмшдэг. Иймээс хөрөнгийн хяналтыг бий болгох өнгөрсөн үйл явдал нь худалдан авалт, татвар ногдох үйл явдал эсвэл шилжүүлэг байж болох юм. Ирээдүйд гарч тохиолдохоор хүлээгдэж буй ажил гүйлгээ буюу үйл явдал нь өөрөө хөрөнгийг бий болгодоггүй. Иймээс тухайлбал; татвар ногдуулах санаа төлөвлөгөө нь татвар төлөгчдөөс шаардах эрх хэлбэрээр хөрөнгө бий болгох өнгөрсөн үйл явдал биш юм.

### **Нөөцийн магадлалт орлогын гүйлгээ**

35. Орлогын гүйлгээ нь гарч тохиолдохгүй байхаас гарч тохиолдох нь илүү магадлалтай байх тохиолдолд нөөцийн орлогын гүйлгээ нь нилээд магадлалтай гэж үздэг. Нөөцийн ижил төрлийн гүйлгээний талаархи өөрийн өнгөрсөн туршлага ба татвар төлөгч буюу шилжүүлэгчийн талаархи хүлээлтэндээ үндэслэн байгууллага нь ийм тодорхойлолтыг гаргадаг. Жишээлбэл; (а) засгийн газар нь улсын секторын байгууллага (тайлагнагч байгууллага)-д мөнгө санг шилжүүлэхийг зөвшөөрсөн, (б) гэрээ нь заавал биелүүлэх гэрээ болсон, (в) засгийн газар нь тохиролцсон нөөцийг шилжүүлж байсан түүхэн туршлагатай тохиолдолд тухайн тайлангийн өдрөөр мөнгө санг шилжүүлээгүй ч гэсэн орлогын гүйлгээ хийгдэх нилээд магадлалтай байдаг.

### **Болзошгүй хөрөнгө**

36. Хөрөнгийн чухал шинжүүдийг агуулсан боловч хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаагүй зүйлсийг болзошгүй хөрөнгө байдлаар тодруулгад тусгаж болох юм (УСНББОУС 19-ийг үзнэ үү).

### **Эздийн хувь оролцоо**

37. Эздийн хувь оролцоог УСНББОУС 1-д тодорхойлсон байдаг. Эздийн хувь оролцоо болох шалгуурыг хангах ажил гүйлгээний хувьд уг тодорхойлолтонд заасан шинж чанаруудыг хангах шаардлагатай юм. Ажил гүйлгээ нь эздийн хувь оролцооны тодорхойлолтыг хангаж буй эсэхийг тогтоохдоо ажил гүйлгээний хэлбэрээс илүү мөн чанарыг харгалзан үзнэ. Эздийн хувь оролцоонд хамаарч болох хэлбэрүүдийг 38-р параграфт дурдсан. Ажил гүйлгээний хэлбэрээс үл хамааран энэ нь зээл буюу бусад төрлийн өр төлбөр, эсвэл орлого гэдэг нь түүний мөн чанараас тодорхой, ойлгомжтой байх тохиолдолд байгууллага нь түүнийг

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

тийм байдлаар хүлээн зөвшөөрөх бөгөөд хэрэв материаллаг бол уг нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн тэмдэглэлд зохих тодруулгыг хийнэ. Жишээлбэл; ажил гүйлгээ нь эздийн хувь оролцоо гэсэн утгатай боловч шилжүүлэгчийн энэхүү хөрөнгө оруулалтын хариуд ирээдүйн тодорхой хугацаанд тухайн тайлагнагч байгууллага нь тогтмол хуваарилалтыг тэрхүү шилжүүлэгчид төлнө гэж тусгайлан заасан бол уг ажил гүйлгээ нь илүү зээлийн шинж чанартай байна. Гэрээ хэлцлийн хувьд байгууллага нь өр төлбөрийг эздийн хувь оролцооноос ялган тодорхойлохдоо УСНББОУС 28, *Санхүүгийн Хэрэглүүр: Топилуулга*-д заасан заавар удирдамжийг мөн харгалзан үзнэ.

38. Эздийн хувь оролцоог тухайлбал, дараах зүйлсээр нотолж болох юм:

- (а) Хувь оролцоог хийхээс өмнө эсвэл хувь оролцоог оруулах үед тухайн хүлээн авагчийн хувь нийлүүлсэн цэвэр хөрөнгө/өмчийн нэг хэсгийг бүрдүүлэх байдлаар тэрхүү хувь оруулагчаас эсвэл түүнийг хянадаг байгуулагаас уг шилжүүлгийн (эсвэл ийм шилжүүлгийн ангийн) талаар гаргасан албан ёсны тодорхойлолт;
- (б) Хүлээн авагчийн цэвэр хөрөнгө/өмч дэх одоогийн санхүүгийн хувь оролцоог борлуулж, шилжүүлж эсвэл эргэлтээс гаргаж болно гэдгийг тогтоосон буюу нэмэгдүүлсэн уг хувь оролцоотой холбоотой албан ёсны гэрээ хэлцэл;
- (в) Хувь оролцоотой холбоотой бөгөөд борлуулж, шилжүүлж эсвэл эргэлтээс гаргаж болох өмчийн хэрэглүүрийн гаргалт.

**Ажил гүйлгээний арилжааны болон арилжааны бус бүрэлдэхүүн хэсгүүд**

39. Байгууллага нь ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг агуулсан нөөцийн хяналтыг эздийн хувь оролцооноос бусад хэлбэрээр олж авах нөхцөл байдлуудыг доорх 40, 41-р параграфт авч үзсэн.

40. Арилжааны болон арилжааны бус ажил гүйлгээг УСНББОУС 9-ийн 11-р параграфт тодорхойлсон бөгөөд ажил гүйлгээ нь арилжааны ба арилжааны бус бүрэлдэхүүн хэсэг гэсэн хоёр бүрэлдэхүүн хэсгийг агуулсан байж болно гэдгийг энэ Стандартын 10-р параграфт тэмдэглэсэн.

41. Арилжааны болон арилжааны бус бүрэлдэхүүн хэсгүүдийг агуулсан ажил гүйлгээгээр хөрөнгийг олж эзэмшсэн тохиолдолд тухайн байгууллага нь бусад УСНББОУС-ын зарчим ба шаардлагуудын дагуу арилжааны бүрэлдэхүүн хэсгийг хүлээн зөвшөөрнө. Арилжааны бус бүрэлдэхүүн хэсгийг энэ Стандартын зарчим ба шаардлагуудын дагуу хүлээн зөвшөөрнө. Ажил гүйлгээ нь ялган тодорхойлж болох арилжааны болон арилжааны бус бүрэлдэхүүн хэсгүүдтэй эсэхийг тогтоохын тулд мэргэжлийн шүүн тунгаалт хийдэг. Арилжааны болон арилжааны бус бүрэлдэхүүн хэсгүүдийг тусад нь ялган тодорхойлох боломжгүй тохиолдолд уг ажил гүйлгээг арилжааны бус ажил гүйлгээ гэж үзнэ.

### **Хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үеийн хэмжилт**

42. **Арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн хөрөнгийг тухайн олж эзэмшсэн өдрөөрх түүний бодит үнэ цэнээр анх хэмжинэ.**
43. Арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн хөрөнгийг УСНББОУС 12, *Бараа Материал*, УСНББОУС 16, *Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө*, УСНББОУС 17-гийн дагуу уг олж эзэмшсэн өдрөөрх тэдгээрийн бодит үнэ цэнээр хэмжинэ.

### **Арилжааны бус ажил гүйлгээний орлогын хүлээн зөвшөөрөлт**

44. **Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөн арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн нөөцийн орлогын гүйлгээг тэрхүү орлогын гүйлгээтэй холбоотойгоор өр төлбөрийг бас хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд орлого гэж хүлээн зөвшөөрнө.**
45. **Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөн арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн нөөцийн орлогын гүйлгээний хувьд өр төлбөр гэж хүлээн зөвшөөрсөн одоогийн үүргийг барагдуулахын хэрээр тухайн байгууллага нь уг хүлээн зөвшөөрсөн өр төлбөрийн дансны үнийг бууруулах ба тэрхүү бууралттай тэнцүү дүнгээр орлогыг хүлээн зөвшөөрнө.**
46. Байгууллага нь арилжааны бус ажил гүйлгээний үр дүн болгон цэвэр хөрөнгийн өсөлтийг хүлээн зөвшөөрдөг тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрнө. Хэрэв арилжааны бус ажил гүйлгээнээс бий болох нөөцийн орлогын гүйлгээний хувьд өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн бөгөөд татвар ногдох үйл явдал гарч тохиолдсон эсвэл нөхцөл биелсэний улмаас тэрхүү өр төлбөрийг дараа нь бууруулсан бол орлогыг хүлээн зөвшөөрнө. Хэрэв нөөцийн орлогын гүйлгээ нь эздийн хувь оролцооны тодорхойлолтыг хангаж байвал үүнийг өр төлбөр эсвэл орлого гэж хүлээн зөвшөөрөхгүй.
47. Орлогыг хүлээн зөвшөөрөх цаг хугацааг тухайн нөхцлийн шинж төрөл болон тэдгээрийн биелэлтээр тодорхойлно. Жишээлбэл; байгууллага нь бараа, үйлчилгээг гуравдагч талд нийлүүлнэ эсвэл зарцуулаагүй мөнгө санг тухайн шилжүүлэгчид буцаан өгнө гэж нөхцөлд тусгайлан заасан бол бараа, үйлчилгээг нийлүүлсэнээр орлогыг хүлээн зөвшөөрнө.

### **Арилжааны бус ажил гүйлгээний орлогын хэмжилт**

48. **Арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн орлогыг тухайн байгууллагын хүлээн зөвшөөрсөн цэвэр хөрөнгийн өсөлтийн дүнгээр хэмжинэ.**
49. Арилжааны бус ажил гүйлгээний үр дүнд байгууллага нь хөрөнгийг хүлээн зөвшөөрдөг бөгөөд өр төлбөрийг бас хүлээн зөвшөөрөх шаардлагатайгаас бусад тохиолдолд 42-р параграфын дагуу хэмжсэн хөрөнгийн дүнтэй тэнцүү хэмжээгээр орлогыг мөн хүлээн зөвшөөрнө. Өр

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

төлбөрийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай тохиолдолд түүнийг 57-р параграфын шаардлагын дагуу хэмжих бөгөөд хэрэв байгаа бол цэвэр хөрөнгийн өсөлтийн дүнгээр орлогыг хүлээн зөвшөөрнө. Татвар ногдох үйл явдал гарч тохиолдсон эсвэл нөхцөл биелсэний үр дүнд өр төлбөрийг дараа нь бууруулсан бол өр төлбөрийн тэрхүү бууралтын дүнг орлого гэж хүлээн зөвшөөрнө.

### **Өр төлбөр гэж хүлээн зөвшөөрсөн одоогийн үүрэг**

50. **Арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн бөгөөд өр төлбөрийн тодорхойлолтыг хангах одоогийн үүргийг зөвхөн дараах тохиолдолд өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө:**
- (а) **Тухайн үүргийг барагдуулахын тулд ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг агуулсан нөөцийг зарцуулах шаардлагатай гэдэг нь нилээд магадлалтай байх; ба**
  - (б) **Үүргийн дүнгийн талаар найдвартай тооцоолол хийж чадах.**

### **Одоогийн үүрэг**

51. Одоогийн үүрэг нь тодорхой арга замаар үйлдэх буюу гүйцэтгэх үүрэг бөгөөд аливаа арилжааны бус ажил гүйлгээний хувьд өр төлбөр үүсгэх үр дүнтэй байж болно. Шилжүүлгийн суурь үндэслэлийг тогтоосон хууль тогтоомж буюу заавал биелүүлэх хэлцэлд заасан болзлоор одоогийн үүргийг хүлээлгэж болох юм. Энэ нь мөн урьдчилж орсон орлогын хүлээн зөвшөөрөлт гэх мэт үйл ажиллагааны хэвийн орчин нөхцлөөс үүсэж болно.
52. Хөрөнгийг тодорхой зорилгоор ашиглана гэсэн болзол тавьсан хууль тогтоомж буюу заавал биелүүлэх бусад хэлцлийн дагуу арилжааны бус ажил гүйлгээгээр олон тохиолдолд татвар ногдуулах буюу улсын секторын байгууллагуудад хөрөнгийг шилжүүлдэг. Жишээлбэл;
- (а) Тусгайлан заасан зорилгоор ашиглалт зарцуулалтыг нь хууль буюу тогтоомжоор хязгаарладаг татвар;
  - (б) Нөхцлүүдийг агуулсан заавал биелүүлэх хэлцлээр олгодог дараах шилжүүлэг:
    - (i) Үндэсний засгийн газраас бүсийн, мужийн буюу орон нутгийн засгийн газарт олгох;
    - (ii) Мужийн/бүсийн засгийн газраас орон нутгийн засгийн газарт олгох;
    - (iii) Засгийн газраас улсын секторын бусад байгууллагуудад олгох;
    - (iv) Хуулиар олгогдсон бүрэн эрх, бүсийн зөвлөл буюу бүрэн эрх гэх мэт үйл ажиллагааны бие даасан эрхтэйгээр тодорхой чиг

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

үүргийг гүйцэтгүүлэхийн тулд хууль тогтоомжоор байгуулсан засгийн газрын агентлагуудад олгох;

- (v) Хандивлагч байгууллагуудаас засгийн газар буюу улсын секторын бусад байгууллагад олгох.

53. Хэвийн үйл ажиллагааны явцад тайлагнагч байгууллага нь татвар ногдох үйл явдал гарч тохиолдохоос өмнө нөөцийг хүлээн зөвшөөрч болох юм. Энэ тохиолдолд уг татвар ногдох үйл явдал гарч тохиолдох хүртэл урьдчилж орсон орлоготой тэнцүү дүнгээр өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.
54. Хэрэв тайлагнагч байгууллага нь шилжүүлгийн заавал биелүүлэх хэлцэл байгуулагдахаас өмнө нөөцийг хүлээн авсан бол уг гэрээ нь заавал биелүүлэх гэрээ болох хүртэл урьдчилж орсон орлогыг өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.

### Шилжүүлсэн хөрөнгийн нөхцөл

55. **Шилжүүлсэн хөрөнгийн нөхцөл нь анх хүлээн зөвшөөрөх үедээ 50-р параграфын дагуу хүлээн зөвшөөрөх одоогийн үүрэг үүсэхэд хүргэдэг.**
56. Болзлыг 7-р параграфт тодорхойлсон. Болзол нь нөхцөл эсвэл хязгаарлалт эсэхийг тодорхойлох заавар удирдамжийг 14-25-р параграфт дурдсан. Тухайн болзол нь нөхцөл эсвэл хязгаарлалт болох эсэхийг тодорхойлохын тулд байгууллага нь нөөцийн орлогын гүйлгээнд хамаарах аливаа болон бүх болзлуудыг шинжилж үзнэ.

### Өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөх үеийн хэмжилт

57. **Өр төлбөр гэж хүлээн зөвшөөрөх дүн нь тухайн тайлангийн өдрөөр уг одоогийн үүргийг барагдуулахад шаардлагатай дүнгийн хамгийн сайн тооцоолол байна.**
58. Өр төлбөр хүлээн зөвшөөрөхөд хүргэсэн үйл явдлын хүрээн дэх эрсдэл ба тодорхойгүй байдлыг уг тооцоололд харгалзан үзнэ. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ нь материаллаг байх тохиолдолд уг үүргийг барагдуулахад шаардагдахаар хүлээгдэж буй дүнгийн өнөөгийн үнэ цэнээр өр төлбөрийг хэмжинэ. Ийм шаардлага нь УСНББОУС 19-д заасан зарчмуудтай нийцэх юм.

### Татвар

59. **Татвар ногдох үйл явдал гарч тохиолдсон ба хөрөнгийг хүлээн зөвшөөрөх шалгуур хангагдсан тохиолдолд байгууллага нь уг татварын хувьд хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.**
60. Байгууллага нь өнгөрсөн үйл явдлын (татвар ногдох үйл явдлын) үр дүнд нөөцийг хяналтандаа авсан бөгөөд тэдгээр нөөцөөс ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг авахаар хүлээгдэж буй

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

тохиолдолд татвараас бий болсон нөөц нь хөрөнгийн тодорхойлолтыг хангана. Нөөцийн орлогын гүйлгээ гарч тохиолдох нилээд магадлалтай бөгөөд түүний бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадах тохиолдолд татвараас бий болсон нөөц нь хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангах юм. Нөөцийн орлогын гүйлгээний магадлалын зэрэг хэмжээг анхны хүлээн зөвшөөрөлтийн үед бэлэн боломжтой байгаа нотолгоонд үндэслэн тодорхойлох бөгөөд үүнд уг татвар ногдох үйл явдлын талаар татвар төлөгчийн хийсэн тодруулга хамаарах боловч түүгээр хязгаарлагдахгүй.

61. Татварын орлого нь бусад байгууллагуудад биш, харин татвар ногдуулдаг зөвхөн засгийн газрын хувьд бий болдог. Жишээлбэл; үндэсний засгийн газар нь өөрийн татварын албаар дамжуулан цуглуулах татварыг ногдуулдаг тохиолдолд хөрөнгө ба орлого нь тэрхүү татварын албанд биш, харин засгийн газарт орох юм. Түүнчлэн, үндэсний засгийн газар нь борлуулалтын татварыг ногдуулдаг бөгөөд түүний нийт орлогыг татварын байнгын ногдуулалтанд үндэслэн мужийн засгийн газарт шилжүүлдэг тохиолдолд уг үндэсний засгийн газар нь тэрхүү татварын хувьд хөрөнгө ба орлогыг хүлээн зөвшөөрч, мужийн засгийн газарт шилжүүлсэн хэмжээгээр хөрөнгийн бууралт болон зардлыг хүлээн зөвшөөрдөг. Мужийн засгийн газар нь тухайн шилжүүлгийн хувьд хөрөнгө ба орлогыг хүлээн зөвшөөрнө. Нэг байгууллага нь бусад хэд хэдэн байгууллагуудын өмнөөс татварыг цуглуулдаг тохиолдолд энэ нь тэдний өмнөөс агентын үүрэг гүйцэтгэж байна. Жишээлбэл; мужийн татварын алба нь мужийн засгийн газар болон хэд хэдэн хотын захиргааны өмнөөс орлогын татварыг цуглуулдаг тохиолдолд уг цуглуулсан татварын хувьд орлого хүлээн зөвшөөрөхгүй. Харин татвар ногдуулж буй тухайн засгийн газар, захиргаа нь уг татварын хувьд хөрөнгө ба орлогыг хүлээн зөвшөөрнө.
62. Татвар төлөх нь (а) уг засгийн газрын үйл ажиллагааны явц дахь ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн хуваарилалтаас, эсвэл (б) тухайн засгийн газар татан буугдсан тохиолдолд өр төлбөрөөс давсан аливаа хөрөнгийн хуваарилалтаас авах эрхийг татвар төлөгчдөд олгодоггүй учраас татвар нь эдийн хувь оролцооны тодорхойлолтыг хангахгүй. Түүнчлэн, татвар төлөх нь уг засгийн газар дахь борлуулж, арилжиж, шилжүүлж эсвэл эргэлтээс гаргаж болох өмчлөлийн эрхийг татвар төлөгчид олгохгүй.
63. Татвар төлөгч нь арилжааны хариуд ойролцоогоор тэнцүү үнэ цэнийг шууд хүлээн авахгүйгээр нөөцийг тухайн засгийн газарт шилжүүлдэг учраас татвар нь арилжааны бус ажил гүйлгээний тодорхойлолтыг хангадаг. Татвар төлөгч нь засгийн газраас явуулж буй нийгмийн өргөн хүрээтэй бодлогоос үр өгөөж хүртэж болох боловч татвар төлсөний шууд хариу төлбөр болгон ийм үр өгөөжийг олгодоггүй.
64. 52-р параграфт заасанчлан, зарим татварыг тусгай зорилгоор ногдуулдаг. Хэрэв засгийн газар нь тусгай зорилго бүхий татварын ногдуулалтын үр дүнд хүлээн зөвшөөрсөн хөрөнгөтэй холбоотой аливаа нөхцлийн хувьд өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай бол тэрхүү нөхцөл биелж, өр төлбөрийг бууруулах хүртэл орлогыг хүлээн зөвшөөрөхгүй. Гэвч уг тусгай



АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

зорилго нь нөхцөл биш, хязгаарлалтанд хүргэдэг учраас тусгай зорилгоор ногдуулсан татвар нь ихэнх тохиолдолд өр төлбөр үүсгэнэ гэж хүлээдэггүй.

**Татвар ногдох үйл явдал**

65. Олон улс оронд ижил төрлийн татварыг ногдуулдаг. Тайлагнагч байгууллага нь ногдуулах янз бүрийн татварын хувьд татвар ногдох үйл явдлыг тодорхойлохын тулд өөрийн улс орны татварын хуулийг судлан шинжилнэ. Хууль буюу зохицуулалтанд өөрөөр зааснаас бусад тохиолдолд дараах зүйлс нь татвар ногдох үйл явдал байх магадлалтай:
- (а) Орлогын татварын хувьд татвар ногдох үйл явдал нь татвар төлөгч уг татварын тайлант хугацаанд татвар ногдох орлого олох;
  - (б) Нэмэгдсэн өртгийн албан татварын хувьд татвар ногдох үйл явдал нь татвар төлөгч уг татварын тайлант хугацаанд татвар ногдох үйл ажиллагаа явуулах;
  - (в) Бараа, ажил үйлчилгээний татварын хувьд татвар ногдох үйл явдал нь уг татварын тайлант хугацаанд татвар ногдох бараа, үйлчилгээг худалдан авах буюу борлуулах;
  - (г) Гаалийн татварын хувьд татвар ногдох үйл явдал нь гаалийн хилээр гаалийн татвар ногдох бараа буюу үйлчилгээг нэвтрүүлэх;
  - (д) Нас баралтын татварын хувьд татвар ногдох үйл явдал нь татвар ногдох үл хөдлөх хөрөнгийг өмчлөгч хүн нас барах;
  - (е) Үл хөрөнгийн татварын хувьд татвар ногдох үйл явдал нь татвар ногдуулах өдөр болох, хэрэв татварыг үечилсэн сууриар ногдуулдаг бол татвар ногдуулах тэрхүү тайлант үе болох.

**Татварын урьдчилж орсон орлого**

66. Татвар ногдох үйл явдал гарч тохиолдохоос өмнө хүлээн авсан татварын хувьд (а) уг татварыг авах тухайн байгууллагын эрхийг үүсгэх үйл явдал гарч тохиолдоогүй, (б) хэдийгээр байгууллага нь нөөцийн орлогын гүйлгээг аль хэдийн хүлээн авсан боловч татварын орлогыг хүлээн зөвшөөрөх шалгуур хангагдаагүй (59-р параграфыг үзнэ үү) учраас хөрөнгө, өр төлбөрийн тодорхойлолт болон 59-р параграфын шаардлагуудын дагуу тэрхүү нөөцийг хөрөнгө ба өр төлбөр (урьдчилж орсон орлого) гэж хүлээн зөвшөөрнө. Татвартай холбоотой урьдчилж орсон орлого нь бусад урьдчилж орсон орлогоос үндсэндээ ялгаагүй байдаг тул тэрхүү татвар ногдох үйл явдал гарч тохиолдох хүртэл өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Татвар ногдох үйл явдал гарч тохиолдсон үед өр төлбөрийг бууруулж, орлогыг хүлээн зөвшөөрнө.

**Татвар ногдох ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгийн хэмжилт**

67. Татвар ногдуулах ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгийг уг олж эзэмшсэн өдрөөрх тэдгээрийн бодит үнэ цэнээр хэмжихийг 42-р параграфтаар

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

шаардсан байдаг. Татвар ногдуулах ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгийг тухайн байгууллагад орох нөөцийн орлогын гүйлгээний хамгийн сайн тооцооллоор хэмжинэ. Тайлагнагч байгууллагууд нь татвар ногдуулах ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгийн хэмжилтийн хувьд нягтлан бодох бүртгэлийн бодлогыг 42-р параграфын шаардлагуудад нийцүүлэн боловсруулна. Эдгээр хөрөнгийг тооцоолох нягтлан бодох бүртгэлийн бодлого нь татвар ногдуулах ажил гүйлгээнээс үүсэх нөөц уг засгийн газарт орох магадлал ба тэрхүү үр дүн болох хөрөнгийн бодит үнэ цэнийн аль алиныг харгалзан тусгана.

68. Татвар ногдох үйл явдал ба татварын цуглуулалтын хооронд хугацааны заагтай байх тохиолдолд улсын секторын байгууллагууд нь тухайлбал, өмнөх тайлант үеүдэд уг татварыг цуглуулж байсан түүхэнд үндэслэсэн статистик загварыг ашигласнаар татвар ногдуулах ажил гүйлгээнээс үүсэх хөрөнгийг найдвартайгаар хэмжиж болох юм. Татвар төлөгчдөөс мөнгөн орлогыг хүлээн авах хугацаа, татвар төлөгчийн гаргасан татварын мэдүүлэг, татварын авлага ба эдийн засгийн бусад үйл явдал хоорондох уялдаа холбоог ийм загварт харгалзан үздэг. Хэмжилтийн загварт мөн дараах гэх мэт хүчин зүйлсийг харгалзан үзнэ:
- (а) Нийтлэг зорилготой санхүүгийн тайлангаа хэвлэн нийтлэхэд засгийн газарт зөвшөөрсөн хугацаанаас илүү урт хугацаанд татварын тайлангаа гаргахыг татвар төлөгчдөд зөвшөөрдөг татварын хууль;
  - (б) Татварын тайлангаа цаг хугацаанд нь гарган танилцуулаагүй татвар төлөгч;
  - (в) Татвар ногдуулах зорилгоор мөнгөн зүйлийн бус хөрөнгийн үнэ цэнэ тогтоолт;
  - (г) Зарим татвар төлөгчдөөс авах татварыг тодорхойлохдоо хугацаа сунгахыг шаарддаг татварын хуулийн нарийн төвөгтэй байдал;
  - (д) Татварын хуулийг хатуу чанд хэрэгжүүлэх ба засгийн газарт хууль ёсоор төлөх бүх татварыг цуглуулах санхүүгийн болон бодлогын зардал нь уг хүлээн авах үр өгөөжөөс илүү давж гарах боломжит байдал;
  - (е) Зарим татварын төлөлтийг хойшлуулахыг татвар төлөгчдөд зөвшөөрдөг татварын хууль;
  - (ж) Тодорхой нэг татвар болон улс оронд тусгайлан хамаарах янз бүрийн нөхцөл байдлууд.
69. Татвар ногдуулах ажил гүйлгээнээс үүсэх хөрөнгө, орлогыг статистик загвар ашиглан хэмжих нь уг хүлээн зөвшөөрсөн хөрөнгө, орлогын дүн тухайн тайлант үеийн хувьд татвар төлөгчдөөс авна гэж дараагийн тайлант үеүдэд тодорхойлсон дүнгээс өөр байх үр дүнтэй байж болох юм. Тооцооллын засварыг УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдааны дагуу хийнэ.*

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

70. Зарим тохиолдолд татвар ногдуулах ажил гүйлгээнээс үүсэх хөрөнгө ба холбогдох орлогыг тухайн татвар ногдох үйл явдал гарч тохиолдсоны дараа тодорхой хугацаа өнгөртөл найдвартайгаар хэмжиж чаддаггүй. Татварын суурь нь хувьсан өөрчлөгддөг бөгөөд найдвартай тооцоолол хийх боломжгүй бол ийм тохиолдол үүсэж болох юм. Олон тохиолдолд татвар ногдох үйл явдал гарч тохиолдсоны дараагийн тайлант үед хөрөнгө, орлогыг хүлээн зөвшөөрч болох юм. Гэвч татвар ногдох үйл явдал нь хөрөнгийн тодорхойлолтыг хангах ба хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг биелүүлэх ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцийн орлогын гүйлгээг бий болгохоос өмнө хэд хэдэн тайлант үе өнгөрөх хэвийн бус нөхцөл байдлууд байдаг. Жишээлбэл; талийгаачийн томоохон эдлэн нь мэргэжилтний үнэлгээг шаардах үнэ цэнэт олон тооны эртний эдлэл ба урлагийн бүтээлтэй учраас түүний хувьд нас баралтын татварын дүнг тодорхойлж, найдвартай хэмжихэд хэдэн жил шаардагдаж болох юм. Иймээс төлбөрийг хүлээн авсан буюу авахаар болох хүртэл уг хүлээн зөвшөөрөлтийн шалгуур хангагдахгүй байж болох билээ.

**Татварын системээр дамжуулан төлсөн зардал ба татварын зарлага**

71. **Татварын орлогыг нийт дүнгээр тодорхойлно. Татварын системээр дамжуулан төлсөн зардлын дүнгээр уг татварын орлогыг бууруулахгүй.**
72. Зарим улс оронд засгийн газар нь чек бичих, татвар төлөгчийн банкны дансанд төлбөрийг шууд хийх, татвар төлөгчийн өмнөөс өөр тооцоог барагдуулах гэх мэт төлбөрийн бусад аргыг ашигласнаар олгох байсан үр өгөөжийг тухайн татвар төлөгчид төлөх тохиромжтой арга хэрэгсэл болгон татварын системийг ашиглаж болох юм. Жишээлбэл; даатгалд хамрагдалтыг дэмжин урамшуулахын тулд засгийн газар нь хувь хүний татварын өр төлбөрийг бууруулах, чекээр төлбөр хийх эсвэл даатгалын компанид төлбөрийг шууд барагдуулах гэх мэт арга замаар тухайн хувь хүний эрүүл мэндийн даатгалын хураамжийн зарим хэсгийг төлж болох юм. Энэ тохиолдолд хувь хүн нь татвараа төлсөн эсэхээс үл хамааран уг дүнг төлнө. Иймээс энэ нь засгийн газрын зардал болох бөгөөд санхүүгийн үр дүнгийн тайланд тусад нь хүлээн зөвшөөрвөл зохино. Татварын системээр дамжуулан төлсөн ийм аливаа зардлын дүнгээр татварын орлогыг нэмэгдүүлнэ.
73. **Татварын орлогыг татварын зарлагын дүнтэй нэгтгэн тусгахгүй.**
74. Ихэнх улс оронд засгийн газар нь санхүүгийн зарим төлөв байдлыг дэмжих ба заримыг хязгаарлахын тулд татварын системийг ашигладаг. Жишээлбэл; зарим улс оронд, орон байр өмчлөгч нь татвар ногдуулах орлогыг тооцоолохдоо өөрийн нийт орлогоос моргейжийн зээлийн хүү болон үл хөдлөх хөрөнгийн татвараа хасахыг түүнд зөвшөөрдөг. Энэ төрлийн хөнгөлөлт нь зөвхөн татвар төлөгчдөд хамаардаг. Хэрэв байгууллага (үүн дотроо, хувь хүн) нь татвар төлдөггүй бол ийм хөнгөлөлт эдлэхгүй. Энэ төрлийн хөнгөлөлтийг татварын зарлага гэж нэрлэдэг.

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

Татварын зарлага нь зардал биш, харин чөлөөлсөн орлого бөгөөд нөөцийн орлогын эсвэл зарлагын гүйлгээ үүсэхэд хүргэхгүй. Өөрөөр хэлбэл, энэ нь татвар ногдуулж буй засгийн газрын хувьд хөрөнгө, өр төлбөр, орлого, зардал бий болгохгүй.

75. Татварын системээр дамжуулан төлсөн зардал ба татварын зарлагын хоорондох гол ялгаа бол татварын системээр дамжуулан төлсөн зардлын хувьд хүлээн авагч нь татвараа төлдөг эсвэл татвараа төлөхийн тулд тодорхой механизмыг ашигладаг эсэхээс үл хамааран түүнд олгогдох боломжтой байдаг. Бусад Стандартаар зөвшөөрснөөс бусад тохиолдолд орлого ба зардлын зүйлсийг харилцан суутгаж, цэвэр дүн гаргахыг УСНББОУС 1-ээр хориглодог. Татварын орлого ба татварын системээр дамжуулан төлсөн зардлыг харилцан суутгаж, цэвэр дүн гаргахыг зөвшөөрөхгүй.

## Шилжүүлэг

76. **Шилжүүлсэн нөөц нь хөрөнгийн тодорхойлолтыг хангах ба хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг биелүүлдэг бол 98-р параграфт зааснаас бусад тохиолдолд байгууллага нь уг шилжүүлгийн хувьд хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.**
77. Шилжүүлэг нь буцалтгүй тусламж, өрөөс чөлөөлөлт, торгууль, өвлүүлсэн хөрөнгө, бэлэг, хандив болон хариу төлбөргүй бараа, үйлчилгээнээс бүрддэг. Эдгээр бүх зүйлс нь хариу болгон ойролцоогоор тэнцүү үнэ цэнийг өгөхгүйгээр нэг байгууллагаас нөгөө байгууллагад нөөцийг шилжүүлдэг нийтлэг шинж чанартай бөгөөд энэ Стандартад тодорхойлсон татвар биш юм.
78. Байгууллага нь өнгөрсөн үйл явдлын (шилжүүлгийн) үр дүнд нөөцийг хяналтандаа авдаг бөгөөд тэдгээр нөөцөөс ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг авахаар хүлээгдэж буй тохиолдолд шилжүүлэг нь хөрөнгийн тодорхойлолтыг хангадаг. Нөөцийн орлогын гүйлгээ гарч тохиолдох нилээд магадлалтай бөгөөд түүний бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадах тохиолдолд шилжүүлэг нь хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангадаг. Зээлдүүлэгч нь өрөөс чөлөөлөх гэх мэт зарим нөхцөл байдалд өмнө нь хүлээн зөвшөөрсөн өр төлбөрийн дансны үнэ буурч болох юм. Ийм тохиолдолд шилжүүлгийн үр дүнд хөрөнгө хүлээн зөвшөөрөхийн оронд байгууллага нь уг өр төлбөрийн дансны үнийг бууруулна.
79. Нөөцийг байгууллагад шилжүүлсэн эсвэл байгууллага нь тухайн шилжүүлэгчээс шаардах хууль ёсны хүчин төгөлдөр эрхтэй тохиолдолд уг байгууллага нь тэрхүү шилжүүлсэн нөөцийн хяналтыг олж авдаг. Нөөцийг шилжүүлэх олон гэрээ хэлцэл нь уг нөөцийн шилжүүлэг хийгдэхээс өмнө бүх талуудын хувьд заавал биелэгдэх шинж чанартай болдог. Гэвч зарим тохиолдолд нэг байгууллага нь нөөцийг шилжүүлэхээр амласан боловч түүнийгээ биелүүлдэггүй. Иймээс (а) нэхэмжлэл нь хууль ёсны хүчин төгөлдөр, ба (б) байгууллага нь нөөцийн орлогын гүйлгээ гарч тохиолдох

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

нилээд магадлалтай гэж үнэлсэн зөвхөн тийм тохиолдолд хөрөнгө, өр төлбөр ба/буюу орлогыг хүлээн зөвшөөрнө. Ийм хугацаа болох хүртэл уг байгууллага нь тэрхүү шилжүүлэхээр санал болгосон нөөцийн үр өгөөжид гуравдагч тал хандан нэвтрэхийг хязгаарлаж эсвэл зохицуулж чадахгүй юм.

80. Эздийн хувь оролцооны тодорхойлолтыг хангах нөөцийн шилжүүлэг нь орлого үүсэхэд хүргэдэггүй. (а) Хүлээн авагч байгууллагын үйл ажиллагааны явц дахь ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн хуваарилалтаас, эсвэл тухайн байгууллага татан буугдсан тохиолдолд өр төлбөрөөс давсан аливаа хөрөнгийн хуваарилалтаас авах эрхийг тэрхүү нөөцийг нийлүүлж буй байгууллагад олгохоор тусгайлан заасан, эсвэл (б) нөөцийг нийлүүлж буй байгууллага нь уг хүлээн авагч байгууллага дахь борлуулж, арилжиж, шилжүүлж эсвэл эргэлтээс гаргаж болох санхүүгийн хувь оролцоог олж эзэмшинэ гэдгийг тусгайлан заасан гэрээ нь мөн чанарын хувьд эздийн хувь оролцоог бий болгох гэрээ юм.
81. Шилжүүлэгч нь уг хүлээн авагч байгууллагаас хариу болгон ойролцоогоор тэнцүү үнэ цэнийг шууд авахгүйгээр нөөцийг тэрхүү хүлээн авагч байгууллагад нийлүүлдэг учраас шилжүүлэг нь арилжааны бус ажил гүйлгээний тодорхойлолтыг хангадаг. Хүлээн авагч байгууллага нь хариу болгон ойролцоогоор тэнцүү үнэ цэнийг өгөхөөр гэрээнд заасан бол уг гэрээ нь шилжүүлгийн гэрээ биш, харин УСНББОУС 9-ийн дагуу тайлагнах арилжааны ажил гүйлгээний гэрээ болох юм.
82. Байгууллага нь уг шилжүүлсэн нөөцийг хүлээн зөвшөөрөх үед өр төлбөр үүсэх эсэхийг тодорхойлохын тулд тухайн шилжүүлгийн гэрээнд агуулагдсан бүх болзлыг шинжилж үзнэ.

**Шилжүүлсэн хөрөнгийн хэмжилт**

83. 42-р параграфт заасанчлан, шилжүүлсэн хөрөнгийг тухайн олж эзэмшсэн өдрөөрх түүний бодит үнэ цэнээр хэмждэг. Байгууллага нь хөрөнгийг хүлээн зөвшөөрөх ба хэмжих нягтлан бодох бүртгэлийн бодлогыг УСНББОУС-д нийцүүлэн боловсруулна. Өмнө дурдсанчлан, арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн бараа материал, үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг УСНББОУС 12, УСНББОУС 16, УСНББОУС 17-гийн шаардлагуудын дагуу уг олж эзэмшсэн өдрөөрх тэдгээрийн бодит үнэ цэнээр анх хэмжинэ. Санхүүгийн хэрэглүүрийг, үүн дотроо мөнгө, түүнчлэн санхүүгийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангах шилжүүлгийн авлага ба бусад хөрөнгийг 42-р параграф болон тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу уг олж авсан өдрөөрх тэдгээрийн бодит үнэ цэнээр бас хэмжинэ.

**Өрөөс чөлөөлөх ба өр төлбөрийг хариуцах**

84. Зээлдүүлэгч нь өрийг бүрмөсөн цуцалснаар улсын секторын байгууллагын төлөх өрийг цуглуулан авах өөрийн эрхээс зарим үед

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

татгалздаг. Жишээлбэл; үндэсний засгийн газар нь орон нутгийн засаг захиргааны төлөх зээлийг хүчингүй болгож болох юм. Энэ тохиолдолд өмнө хүлээн зөвшөөрсөн өр төлбөр барагдаж байгаа учраас орон нутгийн засаг захиргаа нь цэвэр хөрөнгийн өсөлтийг хүлээн зөвшөөрнө.

85. Хуучин өр нь өр төлбөрийн тодорхойлолтыг хангахгүй буюу өр төлбөр гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг биелүүлэхгүй болсон тохиолдолд тэрхүү өрөөс чөлөөлөлт нь эздийн хувь оролцооны тодорхойлолтыг хангахгүй бол байгууллага нь өрөөс чөлөөлөлтийн хувьд орлогыг хүлээн зөвшөөрнө.
86. Хяналт тавигч байгууллага нь өөрийн бүрэн хяналтанд буй байгууллагын төлөх өрийг чөлөөлсөн эсвэл түүний өр төлбөрийг хариуцсан тохиолдолд 37-38-р параграфт заасанчлан, уг ажил гүйлгээ нь эздийн хувь оролцоо байж болох юм.
87. Өрийн чөлөөлөлтөөр үүссэн орлогыг уг чөлөөлсөн өрийн дансны үнээр хэмжинэ.

### **Торгууль**

88. Торгууль нь хууль болон зохицуулалтын шаардлагуудыг хувь хүн буюу бусад байгууллага зөрчсөний үр дагавар болгон шүүх эсвэл хуулийг хэрэгжүүлэгч бусад этгээдийн тодорхойлсны дагуу улсын секторын байгууллагууд нь тэрхүү хувь хүн буюу бусад байгууллагаас хүлээн авсан эсвэл хүлээн авахаар болсон эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи юм. Зарим улс оронд хуулийг хэрэгжүүлэх албан тушаалтан нь хууль зөрчсөн гэж үзсэн хувь хүнд торгууль ногдуулах эрхтэй байдаг. Ийм тохиолдолд тухайн хувь хүн нь ихэвчлэн торгуулийг төлөх эсвэл уг асуудлаар маргахын тулд шүүхэд хандах сонголттой байдаг. Хариуцагч нь шүүхэд хандахын оронд торгуулийг төлөхөөр уг зарга мэдүүлэгчтэй тохиролцоонд хүрсэн тохиолдолд тэрхүү төлбөрийг торгууль гэж хүлээн зөвшөөрнө.
89. Торгууль нь тодорхой мөнгө дүнг засгийн газарт төлөхийг ихэвчлэн байгууллагаас шаарддаг бөгөөд өр төлбөр гэж хүлээн зөвшөөрөх ямар нэг үүргийг засгийн газарт хүлээлгэдэггүй. Иймээс авлага нь 31-р параграфт заасан хөрөнгийн тодорхойлолтыг хангах ба хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг биелүүлж байвал торгуулийг орлого гэж хүлээн зөвшөөрнө. 12-р параграфт дурдсанчлан, байгууллага нь агентын хувьд торгуулийг цуглуулан авдаг тохиолдолд торгууль нь уг цуглуулагч байгууллагын орлого болохгүй. Торгуулиас үүсэх хөрөнгийг тухайн байгууллагад орох нөөцийн орлогын гүйлгээний хамгийн сайн тооцооллоор хэмжинэ.

### **Өвлүүлсэн хөрөнгө**

90. Өвлүүлсэн хөрөнгө нь нас барсан хүний гэрээслэлийн нөхцлүүдийн дагуу хийгдэх шилжүүлэг юм. Тухайн улс орны хууль тогтоомжоос хамааран тухайлбал, гэрээслэгч нас барсан эсвэл гэрээслэлийг албан ёсоор баталсан гэх мэтээр уг байгууллага нь хууль ёсны хүчин төгөлдөр

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

шаардах эрхтэй болсон тохиолдолд тэрхүү өвлүүлсэн хөрөнгийн хувьд ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи бүхий нөөцөд хяналт тавих өнгөрсөн үйл явдал гарч тохиолдсон гэж үздэг.

91. Ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь уг байгууллагад орох нилээд магадлалтай бөгөөд хөрөнгийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадах тохиолдолд хөрөнгийн тодорхойлолтыг хангах өвлүүлсэн хөрөнгийг хөрөнгө ба орлого гэж хүлээн зөвшөөрнө. Гэрээслэгчийн нас баралт ба байгууллага аливаа хөрөнгийг хүлээн авах хооронд нилээд цаг хугацаа өнгөрсөн бол ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн орлогын гүйлгээний магадлалыг тодорхойлох нь төвөгтэй байж болох юм. Нас барсан хүний хөрөнгө нь түүний бүх нэхэмжлэлийн шаардлагыг барагдуулах ба бүх өвлүүлсэн хөрөнгийг хангахад хүрэлцээтэй эсэхийг тухайн байгууллага тодорхойлох шаардлагатай байдаг. Хэрэв гэрээслэл нь маргаантай бол тухайн байгууллагад орох хөрөнгийн магадлалд бас нөлөөлдөг.
92. Өвлүүлсэн хөрөнгийн бодит үнэ цэнийг 97-р параграфт заасанчлан бэлэг, хандивтай ижил арга замаар тодорхойлно. Нас барагчийн өв хөрөнгөнд татвар ногдуулдаг улс орны хувьд татварын алба нь тухайн байгууллагад өвлүүлсэн хөрөнгийн бодит үнэ цэнийг нэгэнт тодорхойлсон байж болох бөгөөд энэ дүнг уг байгууллага авах боломжтой байж болох юм. Өвлүүлсэн хөрөнгийг хүлээн авсан буюу хүлээн авах нөөцийн бодит үнэ цэнээр хэмжинэ.

**Бэлэг, хандив, үүн дотроо хариу төлбөргүй бараа**

93. Бэлэг ба хандив нь хөрөнгийн сайн дурын шилжүүлэг бөгөөд үүнд мөнгө буюу бусад мөнгөн зүйлсийн хөрөнгө, түүнчлэн нэг байгууллага нь нөгөө байгууллагад ихэвчлэн нөхцөл болзолгүйгээр олгох хариу төлбөргүй бараа, үйлчилгээ хамаардаг. Шилжүүлэгч нь байгууллага эсвэл хувь хүн байж болно. Мөнгө буюу бусад мөнгөн зүйлсийн хөрөнгө, хариу төлбөргүй бараагаар олгох бэлэг ба хандивын хувьд ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг агуулсан нөөцийн хяналтыг олж авахад хүргэх өнгөрсөн үйл явдал нь ихэвчлэн тэрхүү бэлэг, хандивыг хүлээн авах үйлдэл байдаг. Хариу төлбөргүй үйлчилгээгээр олгох бэлэг, хандивын хүлээн зөвшөөрөлтийг доорх 98-103-р параграфт авч үзсэн.
94. Хариу төлбөргүй бараа нь арилжааны бус ажил гүйлгээгээр тухайн байгууллагад үнэгүй шилжүүлсэн биет хөрөнгө боловч болзолтой байж болох юм. Олон талын буюу хоёр талын хөгжлийн байгууллагуудын үзүүлдэг гадаадын тусламж нь хариу төлбөргүй барааг ихэвчлэн агуулсан байдаг.
95. Ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь уг байгууллагад орох нилээд магадлалтай бөгөөд хөрөнгийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадах тохиолдолд бэлэг ба хандивыг (хариу төлбөргүй үйлчилгээнээс бусад) хөрөнгө ба орлого гэж хүлээн зөвшөөрнө. Бэлэг ба хандивын хувьд бэлэг буюу хандивыг өгөх үйлдэл нь түүний

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

хууль ёсны эрхийн шилжилт ямагт нэгэн зэрэг явагддаг; ийм тохиолдолд ирээдүйн эдийн засгийн үр өгөөж нь тухайн байгууллагад орох эсэх талаар эргэлзээгүй байдаг.

96. Барааг хүлээн авсан эсвэл барааг хүлээн авах заавал биелүүлэх хэлцэлтэй байх тохиолдолд хариу төлбөргүй барааг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрдөг. Хэрэв хариу төлбөргүй барааг ямар нэг нөхцөлгүй хүлээн авсан бол орлогыг нэн даруй хүлээн зөвшөөрнө. Хэрэв нөхцөлтэй авсан бол өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх бөгөөд нөхцөл биелэгдсэнээр өр төлбөрийг бууруулж, орлогыг хүлээн зөвшөөрнө.
97. Бэлэг ба хандивыг, үүн дотроо хариу төлбөргүй барааг анх хүлээн зөвшөөрөхдөө уг олж эзэмшсэн өдрөөрх тэдгээрийн бодит үнэ цэнээр хэмждэг. Бодит үнэ цэнийг идэвхитэй зах зээлийн үнээр эсвэл үнэлгээгээр тогтоож болох юм. Хүлээн зөвшөөрөгдсөн ба холбогдох мэргэжлийн шалгуурыг хангасан, үнэлгээний мэргэжлийн байгууллагын гишүүн нь хөрөнгийн үнэ цэнийн үнэлгээг ихэвчлэн хийдэг. Олон хөрөнгийн хувьд идэвхтэй ба хөрвөх зах зээлийн жишиг үнийг лавлагаа болгосноор бодит үнэ цэнийг шууд тодорхойлох боломжтой байдаг. Жишээлбэл; газар, тусгай зориулалтын бус барилга байгууламж, тээврийн хэрэгсэл болон олон төрлийн тоног төхөөрөмжийн хувьд одоогийн зах зээлийн үнийг ихэвчлэн шууд олж авах боломжтой байдаг.

#### **Хариу төлбөргүй үйлчилгээ**

98. **Байгууллага нь хариу төлбөргүй үйлчилгээг орлого ба хөрөнгө гэж хүлээн зөвшөөрч болох боловч хүлээн зөвшөөрөхийг түүнээс заавал шаарддаггүй.**
99. Хариу төлбөргүй үйлчилгээ нь хувь хүмүүс арилжааны бус ажил гүйлгээгээр улсын секторын байгууллагад үзүүлдэг үйлчилгээ юм. Байгууллагад ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи оруулахаар хүлээгдэж буй нөөцийг уг байгууллага нь хяналтандаа авсан учраас эдгээр үйлчилгээ нь хөрөнгийн тодорхойлолтыг хангана. Гэвч ийм хөрөнгийг нэн даруй ашиглан зарцуулдаг бөгөөд эдгээр хариу төлбөргүй үйлчилгээний ашиглалт зарцуулалтыг тусгахын тулд тэнцүү үнэ цэнэ бүхий ажил гүйлгээг бас хүлээн зөвшөөрдөг. Жишээлбэл; багш нарын тусламжаар тэдний сайн дурын үйлчилгээг хүлээн авсан бөгөөд уг үйлчилгээний бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадах сургууль нь хөрөнгө ба орлогын өсөлтийг хүлээн зөвшөөрөх боловч мөн тэрхүү хөрөнгийн бууралт ба зардлыг хүлээн зөвшөөрөх юм. Олон тохиолдолд байгууллага нь хариу төлбөргүй үйлчилгээний ашиглалт зарцуулалтын хувьд зардлыг хүлээн зөвшөөрдөг. Гэвч хөрөнгийг барьж байгуулахад хариу төлбөргүй үйлчилгээг бас ашиглаж болох бөгөөд энэ тохиолдолд уг хариу төлбөргүй үйлчилгээний хувьд хүлээн зөвшөөрсөн дүнг тэрхүү барьж буй хөрөнгийн өртөгт тусган оруулдаг.



АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

100. Улсын секторын байгууллага нь нийтийн эрх ашгийн төлөө хэрэгжүүлж буй сайн дурын буюу сайн дурын бус хөтөлбөрийн дагуу хариу төлбөргүй үйлчилгээг хүлээн авагч байж болох юм. Тухайлбал;
- (а) Бусад засгийн газар буюу олон улсын байгууллагаас авсан техникийн туслалцаа;
  - (б) Зөрчил гаргасан хүмүүс нь улсын секторын байгууллагад нийгмийн үйлчилгээ үзүүлэх шаардлагатай байж болох юм;
  - (в) Улсын эмнэлэг нь сайн дурын ажилтны үйлчилгээ авч болно;
  - (г) Улсын сургууль нь багшийн туслагч эсвэл удирдах зөвлөлийн гишүүн байдлаар эцэг эхчүүдээс сайн дурын үйлчилгээг авч болох юм;
  - (д) Орон нутгийн засаг захиргаа нь гал унтраахад сайн дурын үйлчилгээг авч болно.
101. Байгууллага нь тухайн үзүүлсэн үйлчилгээний хувьд хангалттай хяналтгүй байдаг учраас зарим хариу төлбөргүй үйлчилгээ нь хөрөнгийн тодорхойлолтыг хангадаггүй. Өөр зарим тохиолдолд байгууллага нь хариу төлбөргүй үйлчилгээний хувьд хяналттай боловч тэдгээрийг найдвартай хэмжих боломжгүй байж болно. Иймээс энэ нь хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангадаггүй. Гэвч байгууллага нь үндэсний буюу олон улсын зах зээлээс шууд авч болох мэргэжлийн болон бусад хариу төлбөргүй үйлчилгээ гэх мэт зарим хариу төлбөргүй үйлчилгээний бодит үнэ цэнийг хэмжих боломжтой байж болох юм. 100-р параграфт дурдсан, хариу төлбөргүй үйлчилгээний төрлүүдийн хувьд бодит үнэ цэнийг тодорхойлох үедээ байгууллага нь тэдгээр үйлчилгээний үнэ цэнэ материаллаг бус гэж дүгнэж болох юм. Ихэнх тохиолдолд мэдлэг сургалт багатай буюу мэдлэг сургалтгүй хүмүүс нь хариу төлбөргүй үйлчилгээг үзүүлдэг бөгөөд хэрэв ийм хариу төлбөргүй үйлчилгээ байгаагүй бол тухайн байгууллагаас худалдан авах байсан үйлчилгээнээс энэ нь ихээхэн өөр байдаг.
102. Хариу төлбөргүй үйлчилгээг хяналтандаа авах боломж ба үйлчилгээний бодит үнэ цэнийн хэмжилт гэх мэт ийм үйлчилгээтэй холбоотой олон тодорхойгүй байдлын улмаас энэ Стандарт нь хариу төлбөргүй үйлчилгээг хүлээн зөвшөөрөхийг шаарддаггүй. Гэвч тухайн тайлант үеийн туршид хүлээн авсан хариу төлбөргүй үйлчилгээний шинж чанар ба төрлийн талаар тодруулга хийхийг 108-р параграфтаар дэмжсэн байдаг. Бүх тодруулгын адилаар хариу төлбөргүй үйлчилгээтэй холбоотой тодруулгыг зөвхөн материаллаг байх тохиолдолд хийнэ. Зарим улсын секторын байгууллагын хувьд сайн дурын хүмүүсийн үзүүлсэн үйлчилгээ нь дүнгийн хувьд материаллаг биш боловч мөн чанарын хувьд материаллаг байж болох юм.
103. Хариу төлбөргүй үйлчилгээний ангийг тайлагнах нягтлан бодох бүртгэлийн бодлогыг боловсруулахдаа янз бүрийн хүчин зүйлсийг, үүн дотроо тухайн байгууллагын санхүүгийн байдал, үр дүн, мөнгөн гүйлгээнд

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

тэдгээр хариу төлбөргүй үйлчилгээний үзүүлэх үр нөлөөг харгалзан үзнэ. Байгууллага нь өөрийн зорилгыг биелүүлэхэд хариу төлбөргүй үйлчилгээнээс хамааралтай байх тохиолдолд энэ нь ийм хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийн талаар уг байгууллагын боловсруулах нягтлан бодох бүртгэлийн бодлогод нөлөөлж болох юм. Тухайлбал; өөрийн зорилгыг биелүүлэхэд хариу төлбөргүй үйлчилгээнээс хамааралтай байдаг байгууллага нь хөрөнгийн тодорхойлолтыг хангах ба хүлээн зөвшөөрөх шалгуурыг биелүүлэх тийм хариу төлбөргүй үйлчилгээний ангийг хүлээн зөвшөөрөх илүү их магадлалтай байж болох юм. Хариу төлбөргүй үйлчилгээний ангийг хүлээн зөвшөөрөх эсэхийг тодорхойлохдоо ижил орчинд үйл ажиллагаа явуулж буй адилтгах байгууллагуудын практикыг мөн харгалзан үздэг.

### **Амлалт**

104. Амлалт нь хүлээн авагч байгууллагад хөрөнгийг шилжүүлэх хууль ёсны бус үүрэг хариуцлага юм. Хүлээн авагч нь уг амласан зүйлд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхид тухайн шилжүүлэгч хандан нэвтрэхэд хяналт тавьж чадахгүй учраас амлалт нь хөрөнгийн тодорхойлолтыг хангахгүй. Байгууллага нь уг амласан зүйлсийг хөрөнгө буюу орлого гэж хүлээн зөвшөөрөхгүй. Хэрэв амласан зүйлийг тухайн хүлээн авагч байгууллагад дараа нь шилжүүлэн өгвөл үүнийг дээрх 93-97-р параграфын дагуу бэлэг эсвэл хандив гэж хүлээн зөвшөөрнө. УСНББОУС 19-ийн шаардлагуудын дагуу амлалтын хувьд болзошгүй хөрөнгө байдлаар тодруулга хийж болох юм.

### **Шилжүүлгийн урьдчилж орсон орлого**

105. Шилжүүлгийн гэрээ нь заавал биелүүлэх гэрээ болохоос өмнө байгууллага нь нөөцийг хүлээн авсан тохиолдолд хэрэв нөөц нь хөрөнгийн тодорхойлолтыг хангах ба хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг биелүүлж байвал түүнийг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө. Хэрэв шилжүүлгийн гэрээ нь заавал биелүүлэх гэрээ хараахан болоогүй бол байгууллага нь урьдчилж орсон орлогын хувьд өр төлбөрийг бас хүлээн зөвшөөрнө. Шилжүүлэгтэй холбоотой урьдчилж орсон орлого нь бусад урьдчилж орсон орлогоос үндсэндээ ялгаагүй байдаг тул шилжүүлгийн гэрээг заавал биелүүлэх гэрээ болгох үйл явдал гарч тохиолдох ба уг гэрээний бусад бүх нөхцлүүд биелэх хүртэл өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Тухайн үйл явдал гарч тохиолдсон ба гэрээний бусад бүх нөхцөл биелсэн тохиолдолд өр төлбөрийг бууруулж, орлогыг хүлээн зөвшөөрнө.

### **Хөнгөлөлттэй зээл**

- 105А. Хөнгөлөлттэй зээл нь зах зээлийн нөхцлөөс хөнгөлөлттэйгээр уг байгууллагын авсан зээл юм. Аливаа хүүний төлбөрийн хамт буцаан төлөх зээлийн хэсэг нь арилжааны ажил гүйлгээ болох бөгөөд түүнийг УСНББОУС 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*-ийн дагуу тайлагнана. Анх хүлээн зөвшөөрөх үеийн ажил гүйлгээний үнэ

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

(зээлийн орлого) ба зээлийн бодит үнэ цэнийн (УСНББОУС 29-ийг үзнэ үү) хоорондох аливаа зөрүү нь энэ Стандартын дагуу тайлагнавал зохих арилжааны бус орлого эсэхийг байгууллага нь харгалзан үзнэ.

- 105Б. Анх хүлээн зөвшөөрөх үеийн ажил гүйлгээний үнэ (зээлийн орлого) ба уг зээлийн бодит үнэ цэнийн хоорондох зөрүүг байгууллага нь арилжааны бус орлого гэж тодорхойлсон бол одоогийн үүрэгтэй, жишээлбэл; шилжүүлсэн хөрөнгөнд тогтоосон тусгай нөхцөл нь тухайн хүлээн авагчид одоогийн үүрэг үүсгэх үр дүнтэй байхаас бусад тохиолдолд байгууллага нь тэрхүү зөрүүг орлого гэж хүлээн зөвшөөрнө. Харин одоогийн үүрэгтэй бол уг зөрүүг өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө. Байгууллага нь тэрхүү одоогийн үүргийг барагдуулахын хэрээр өр төлбөрийг бууруулж, түүнтэй тэнцүү дүнгээр орлогыг хүлээн зөвшөөрнө.

## Тодруулга

106. **Байгууллага нь нийтлэг зорилготой санхүүгийн тайланд эсвэл түүний тодруулгад дараах зүйлсийг толилуулна:**
- (a) **Тухайн тайлант үед хүлээн зөвшөөрсөн арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн орлогын дүнг гол ангиудаар толилуулах ба доорх зүйлсийг тусад нь харуулах;**
    - (i) **Татвар, үүнд татварын гол ангиудыг тусад нь харуулах; ба**
    - (ii) **Шилжүүлэг, үүнд шилжүүлгийн орлогын гол ангиудыг тусад нь харуулах.**
  - (б) **Арилжааны бус орлогын хувьд хүлээн зөвшөөрсөн авлагын дүн;**
  - (в) **Нөхцөлтэй шилжүүлсэн хөрөнгийн хувьд хүлээн зөвшөөрсөн өр төлбөрийн дүн;**
  - (в.А) **Шилжүүлсэн хөрөнгийн нөхцөлд хамаарах хөнгөлөлттэй зээлийн хувьд хүлээн зөвшөөрсөн өр төлбөрийн дүн;**
  - (г) **Хязгаарлалтанд хамаарах тухайн хүлээн зөвшөөрсөн хөрөнгийн дүн ба тэдгээр хязгаарлалтын шинж төрөл;**
  - (д) **Арилжааны бус ажил гүйлгээний хувьд аливаа урьдчилж орсон орлогын оршин байдал ба түүний дүн;**
  - (е) **Чөлөөлсөн аливаа өр төлбөрийн дүн.**
107. **Байгууллага нь нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн тодруулгад дараах зүйлсийг толилуулна:**
- (a) **Арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн орлогын хүлээн зөвшөөрөлтийн хувьд баримталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого;**

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

- (б) **Арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн орлогын гол ангиудын хувьд нөөцийн орлогын гүйлгээний бодит үнэ цэнийг хэмжсэн суурь;**
- (в) **Байгууллага нь татвар ногдох үйл явдал гарч тохиолдсон тайлант үед найдвартай хэмжиж чадахгүй татварын орлогын гол ангиудын хувьд тэрхүү татварын шинж төрлийн талаархи мэдээлэл; ба**
- (г) **Өвлүүлсэн хөрөнгө, бэлэг, хандивын гол ангиудын шинж чанар ба төрөл, үүнд хүлээн авсан хариу төлбөргүй барааны гол ангиудыг тусад нь харуулах.**
108. Байгууллага нь хүлээн авсан хариу төлбөргүй үйлчилгээнийхээ, түүнчлэн хүлээн зөвшөөрч тайлагнаагүй ийм үйлчилгээнийхээ гол ангиудын шинж чанар ба төрлийг тодруулахыг сайшаан дэмжинэ. Хариу төлбөргүй үйлчилгээний тухайн нэг ангиас уг байгууллага хамааралтай байх хэмжээ нь тэрхүү ангийн хувьд түүний хийх тодруулгыг тодорхойлно.
109. 106 болон 107-р параграфуудаар шаардсан тодруулга нь шийдвэр гаргалтанд ач холбогдолтой мэдээллээр хангах, түүнчлэн тухайн байгууллагад хариуцуулан өгсөн нөөцийн хувьд өөрийн хариуцлагатай байдлыг харуулах гэсэн УСНББОУС 1-д заасан санхүүгийн тайлагналын зорилтуудаа уг тайлагнагч байгууллага биелүүлэхэд туслалцаа үзүүлдэг.
110. Орлогын гол ангиудын талаархи тодруулга нь тухайн орлогын урсгалын хувьд уг байгууллагын хүлээх эрсдлийн талаар мэдээлэл бүхий шүүн тунгаалт хийхэд хэрэглэгчдэд тусалдаг.
111. Нөхцөл ба хязгаарлалт нь хөрөнгийн ашиглалтанд хязгаарлалт тогтоодог бөгөөд энэ нь тухайн байгууллагын үйл ажиллагаанд нөлөө үзүүлдэг. (а) нөхцлийн хувьд хүлээн зөвшөөрсөн өр төлбөрийн дүн, болон (б) хязгаарлалтанд хамаарах хөрөнгийн дүнгийн талаархи тодруулга нь тухайн байгууллага өөрийн хүсэл зоригоор хөрөнгөө ашиглах түүний чадвар, боломжийн талаар шүүн тунгаалт хийхэд хэрэглэгчдэд тусалдаг. Байгууллага нь тодруулах шаардлагатай мэдээллийг 106(в) параграфт заасан ангиудаар салган задлахыг дэмжинэ.
112. 106(д) параграф нь арилжааны бус ажил гүйлгээний хувьд урьдчилж орсон орлогын оршин байдлыг тодруулахыг байгууллагуудаас шаарддаг. Хэрэв татвар ногдох үйл явдал гарч тохиолдохгүй эсвэл шилжүүлгийн гэрээ нь заавал биелүүлэх гэрээ болохгүй бол тухайн байгууллага нь ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи алдахад хүргэх эрсдлийг эдгээр өр төлбөр нь агуулж байдаг. Эдгээр урьдчилж орсон орлогын тодруулга нь тухайн байгууллагын ирээдийн орлого болон цэвэр хөрөнгийн төлөв байдлын талаар шүүн тунгаалт хийхэд хэрэглэгчдэд туслах юм.
113. 68-р параграфт дурдсанчлан, олон тохиолдолд байгууллага нь тухайлбал, статистик загвар ашигласнаар татвар ногдуулах ажил гүйлгээнээс бий болох хөрөнгө ба орлогыг найдвартай хэмжих боломжтой байдаг. Гэвч

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

тухайн татвар ногдох үйл явдал гарч тохиолдсоноос хойш нэг буюу хэд хэдэн тайлант үе өнгөрөх хүртэл уг байгууллага нь үүссэн хөрөнгө ба орлогыг найдвартай хэмжих боломжгүй тийм хэвийн бус нөхцөл байдлууд байж болох юм. Ийм тохиолдолд байгууллага нь уг татвар ногдох үйл явдал гарч тохиолдсон тайлант үед найдвартай хэмжиж чадахгүй, иймээс хүлээн зөвшөөрөөгүй татварын гол ангиудын шинж төрлийн талаар тодруулга хийнэ. Ийм тодруулга нь тухайн байгууллагын ирээдийн орлого болон цэвэр хөрөнгийн төлөв байдлын талаар мэдээлэл бүхий шүүн тунгаалт хийхэд хэрэглэгчдэд тусалдаг.

114. 107(г) параграф нь хүлээн авсан бэлэг, хандив болон өвлүүлсэн хөрөнгийн гол ангиудын шинж чанар ба төрлийн талаар тодруулга хийхийг байгууллагуудаас шаарддаг. Нөөцийн эдгээр орлогын гүйлгээг тухайн шилжүүлэгчийн хүсэл зоригоор хүлээн авдаг бөгөөд энэ нь ирээдүйн тайлант үеүдэд уг нөөцийн эх үүсвэр мэдэгдэхүйц өөрчлөгдөх эрсдлийг тухайн байгууллагад хүлээлгэдэг. Ийм тодруулга нь тухайн байгууллагын ирээдийн орлого болон цэвэр хөрөнгийн төлөв байдлын талаар мэдээлэл бүхий шүүн тунгаалт хийхэд хэрэглэгчдэд тусалдаг.
115. Хариу төлбөргүй үйлчилгээ нь хөрөнгийн тодорхойлолтыг хангах ба хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг биелүүлдэг тохиолдолд байгууллага нь тэдгээр хариу төлбөргүй үйлчилгээг хүлээн зөвшөөрч, бодит үнэ цэнээр нь хэмжих сонголт хийж болох юм. Байгууллага нь хүлээн авсан хариу төлбөргүй үйлчилгээг хүлээн зөвшөөрсөн эсвэл хүлээн зөвшөөрөөгүй эсэхээс үл хамааран тэдгээр бүх үйлчилгээний шинж чанар ба төрлийн талаар тодруулга хийхийг 108-р параграфт сайшаан дэмжсэн байдаг. Ийм тодруулга нь (а) байгууллагын зорилтуудыг биелүүлэхэд тухайн тайлант үеийн туршид уг үйлчилгээний оруулсан хувь нэмэр, (б) тэрхүү байгууллага нь ирээдүйд өөрийн зорилтуудад хүрэхдээ ийм үйлчилгээнээс хэр зэрэг хамааралтай байгаа талаар мэдээлэл бүхий шүүн тунгаалт хийхэд хэрэглэгчдэд тусалж болох юм.

## Шилжилтийн нөхцөл

116. [Хассан]
117. [Хассан]
118. [Хассан]
119. [Хассан]
120. [Хассан]
121. [Хассан]
122. [Хассан]
123. [Хассан]

## Хүчин төгөлдөр болох хугацаа

124. Байгууллага нь энэхүү Стандартыг 2008 оны 6 дугаар сарын 30-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2008 оны 6 дугаар сарын 30-наас өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 124А. УСНББОУС 28-ын үр дүнд 37-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2013 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Хэрэв байгууллага нь 2013 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед УСНББОУС 28-ыг мөрдсөн бол уг нэмэлт өөрчлөлтийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.
- 124Б. УСНББОУС 29-ийн үр дүнд 5, 10, 87, 106-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулж, 105А, 105Б параграфуудыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2013 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Хэрэв байгууллага нь 2013 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед УСНББОУС 29-ийг мөрдсөн бол эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.
- 124В. 2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-ийн үр дүнд 116, 117, 118, 119, 120, 121, 122, 123, 125-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед УСНББОУС 33-ыг мөрдсөн бол эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.
- 124Г. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 3, 4-р параграфуудыг хассан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 124Д. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийн үр дүнд 1, 2, 6-р параграфуудад нэмэлт өөрчлөлт

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

**оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.**

125. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

## Дүгнэлтийн Үндэслэл

Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 23-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

- ДҮ1. УСНББОУС 23-ын дүгнэлтүүдэд хүрэхдээ УСНББОУС3-ийн харгалзан үзсэн зүйлсийг энэхүү Дүгнэлтийн Үндэслэлд нэгтгэн товчоолсон. УСНББОУС3-ийн хувь хүн гишүүд нь зарим хүчин зүйлсэд бусдаас илүү ач холбогдол өгч байсан. Өөрсдийн үзэл санааг гаргахдаа УСНББОУС3-ийн гишүүд нь дараах зүйлсийг илүү гүнзгий харгалзан үзсэн. Үүнд: (а) 2004 оны 01 дүгээр сард гаргасан, Саналын Урилга (СУ), *Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Үүн дотроо, Татвар ба Шилжүүлэг)*-д арилжааны бус орлогын талаар Удирдах Хорооны илэрхийлсэн үзэл санаа, (б) уг СУ-ын талаархи зөвлөх хэлэлцүүлэгт хариу өгсөн санал гаргагчдын илэрхийлсэн үзэл санаа, (в) Саналын Төсөл (СТ) 29, *Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Үүн дотроо, Татвар ба Шилжүүлэг)*-д хариу өгсөн санал гаргагчдын үзэл санаа.
- ДҮ2. Энэхүү УСНББОУС-ыг боловсруулахдаа, УСНББОУС3 нь НББОУС3-өөс гаргасан холбогдох СТОУС-ууд, ялангуяа Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) 20, *Засгийн Газрын Буцалтгүй Тусламжийн Нягтлан Бодох Бүртгэл ба Засгийн Газрын Тусалцааны Тодруулга* болон НББОУС 41, *Хөдөө Аж Ахуй*-н нөхцөл, заалтуудыг харгалзан үзсэн.
- ДҮ3. УСНББОУС3 нь орлогын хүлээн зөвшөөрөлтийн талаар НББОУС3-өөс хэрэгжүүлж буй төсөл, мөн НББОУС3-ийн Саналын Төсөл, “НББОУС 37 *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-д Оруулах Санал Болгосон Өөрчлөлтүүд”-ийг мэдэж байсан. УСНББОУС3 нь эдгээр төслүүдийг цаашид хянан үнэлэх бөгөөд СТОУС-уудын аливаа өөрчлөлтүүдийн УСНББОУС-уудад болон УСНББОУС3-ийн төслүүдэд үзүүлэх нөлөөллийг тохиромжтой үед нь харгалзан үзнэ. Гэвч УСНББОУС3 нь НББОУС3-ийн албан ажиллагааны үр дүнг түрүүлж хүлээн авах ба СТОУС-уудад орох өөрчлөлтийг урьдчилан харгалзах нь зохисгүй гэж үзсэн. Мөн түүнчлэн, НББОУС3-ийн төслүүдийн үр дүнг хүлээж, энэхүү УСНББОУС-ыг гаргахгүй хойшлуулах нь улсын секторын олон байгууллагуудад арилжааны бус орлогын үзүүлэх ач холбогдолтой байдлыг харгалзан үзвэл тохиромжтой бус гэж УСНББОУС3 үзсэн.

## Оршил

- ДҮ4. Засгийн газар болон улсын секторын бусад олон байгууллагууд нь өөрийн орлогын ихэнх хэсгийг арилжааны бус ажил гүйлгээнээс олдог. Ийм ажил гүйлгээнд үндсэндээ татвар, мөн түүнчлэн шилжүүлэг хамаардаг. Ажил гүйлгээний эдгээр төрлүүдийг энэхүү УСНББОУС-д улсын секторын байгууллагын зүгээс авч үзсэн.
- ДҮ5. 2002 онд УСНББОУС3 (үүний дараа Улсын Секторын Хороо) нь арилжааны бус ажил гүйлгээний (үүн дотроо, татвар ба шилжүүлэг)



АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

орлогын хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтэнд зориулсан УСНББОУС-ыг боловсруулах төсөл санаачлан эхлүүлсэн. Үүнтэй холбоотой асуудлуудыг судалж үзэх ба анхны санал зөвлөмж гаргах СУ-ыг боловсруулахын тулд УСНББОУСЗ нь Удирдах Хороог байгуулсан. Удирдах Хороо нь янз бүрийн улс орнуудын улсын секторын санхүүгийн тайлагналын экспертүүдээс бүрдэж байсан бөгөөд УСНББОУСЗ-ийн гишүүн тус хороог даргалсан. СУ-ыг 2004 оны 01 дүгээр сард гаргасан бөгөөд 2004 оны 6 дугаар сарын 30-наар саналаа ирүүлэхийг хүссэн. Тавин нэгэн санал хүлээн авсан. 2004 оны 11 дүгээр сард УСНББОУСЗ нь тэдгээр саналуудыг шинжилж, СТ 29-ийн төслийг боловсруулж эхэлсэн. СТ 29-ийг 2006 оны 01 дүгээр сард гаргасан бөгөөд 2006 оны 6 дугаар 30-ны дотор саналаа ирүүлэхийг хүссэн.

ДҮ6. 2006 оны 11 дүгээр сард УСНББОУСЗ нь СТ 29-д өгсөн хариултуудад гүнзгий шинжилгээ хийж, энэхүү УСНББОУС-ыг бэлтгэсэн ба гаргахыг зөвшөөрсөн.

### **Хандлага**

ДҮ7. Энэхүү Стандарт нь арилжааны бус ажил гүйлгээний орлогыг хүлээн зөвшөөрөх ерөнхий зарчмуудыг тогтоож, засгийн газар болон улсын секторын бусад байгууллагуудын орлогын гол эх үүсвэрүүдэд тэдгээр зарчмуудыг мөрдөх талаархи заавар удирдамжаар хангадаг. Энэ Стандартыг боловсруулахдаа, УСНББОУСЗ нь арилжааны бус ажил гүйлгээний янз бүрийн тодорхой төрлүүдээс үүсэх орлогын тайлагналд зориулсан шаардлагуудыг боловсруулахад чиглэгдсэн тийм хандлага баримтлах эсэхийг авч үзсэн. Гэвч ийм хандлага нь арилжааны бус ажил гүйлгээний бүх орлогод зориулсан дэлгэрэнгүй заавар удирдамжаар хангахгүй тийм Стандарт гаргах үр дагавар бүхий эрсдэлтэй гэсэн Удирдах Хорооны үзэл санааг УСНББОУСЗ нь цохон тэмдэглэж, хүлээн зөвшөөрсөн. УСНББОУСЗ-ийн үзэл бодлоор бол энэ Стандартад баримталсан хандлага нь арилжааны бус ажил гүйлгээний орлогын хүлээн зөвшөөрөлтөнд зориулсан зохих ерөнхий зарчмуудыг тогтоосон ба арилжааны бус ажил гүйлгээний бүх орлогод түүнийг мөрдөх боломжтой юм.

### **Байгууллагын нэгдэл**

ДҮ8. Анх гаргах үед энэ Стандарт нь арилжааны бус ажил гүйлгээний үр дүн болох байгууллагын нэгдэл нь орлого үүсэхэд хүргэх эсэхийг тусгайлан заадаггүй байсан. Яагаад гэвэл, УСНББОУСЗ нь улсын сектор дахь байгууллагын нэгдлийн санхүүгийн тайлагналыг, үүн дотроо улсын секторын байгууллагуудад СТОУС 3, *Бизнесийн Нэгдэл*-ийн мөрдөгдөх боломжит байдлыг харгалзан авч үзээгүй байсан.

ДҮ8А. Харин дараа нь УСНББОУСЗ нь УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийг гаргасан. УСНББОУС 40 нь улсын секторын нэгдлийн тайлагнал, үүн дотроо аливаа олз буюу гарзын тайлагналыг тусгайлан

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

заасан байдаг. Иймээс улсын секторын нэгдлийг энэ Стандартын цар хүрээнд хамруулдаггүй.

### **Мөнгөн зүйлийн болон мөнгөн зүйлийн бус хөрөнгө**

ДҮ9. Энэхүү Стандарт нь мөнгөн зүйлийн хөрөнгө байдлаар хүлээн авсан буюу хүлээн авах орлого ба мөнгөн зүйлийн бус хөрөнгө байдлаар хүлээн авсан буюу хүлээн авах орлогын хувьд ялгаатай шаардлагуудыг тогтоогоогүй. Мөнгөн зүйлийн бус хөрөнгө нь хэмжилтийн нэмэлт асуудлуудыг үүсгэдэг боловч санхүүгийн тайлагналын өөр арга хандлагыг өөрсдөө шаардахгүй гэж УСНББОУСЗ үзсэн.

### **Болзлын хууль ёсны хүчин төгөлдөр байдал**

ДҮ10. Шилжүүлсэн хөрөнгийн ашиглалтыг хязгаарладаг шилжүүлгийн гэрээ, хууль тогтоомж буюу заавал биелүүлэх бусад хэлцлийн нэр томъёо болгон энэ Стандартад болзол, нөхцөл, хязгаарлалт гэсэн нэр томъёог тодорхойлсон. Болзол, нөхцөл, хязгаарлалт нь хэрэгжихийн тулд хууль ёсны хүчин төгөлдөр байх ёстой гэсэн үзэл санааг энэ Стандартад тусгасан. Шилжүүлсэн хөрөнгийн ашиглалтанд тавигдах болзол нь хууль тогтоомж буюу заавал биелүүлэх бусад хэлцэлд агуулагдах бөгөөд тодорхойлолт ёсоор энэ нь хууль ёсны хүчин төгөлдөр байна гэсэн зарчмыг СУ болон СТ 29-д бас тусгасан байдаг. Орлогын хүлээн зөвшөөрөлтийг зохисгүйгээр саатуулан хойшлуулахаас, эсвэл мөн чанарын хувьд байхгүй хязгаарлалтын талаар тодруулга хийхээс сэргийлэхэд энэ зарчим зайлшгүй шаардлагатай гэж УСНББОУСЗ үзсэн.

### **Болзол - Нөхцөл**

ДҮ11. Хөрөнгийн шилжүүлэг нь түүний хүлээн авагчид нөхцөл хүлээлгэдэг тохиолдолд уг хүлээн авагч нь тухайн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үедээ тэрхүү шилжүүлгийн хувьд өр төлбөр хүлээн зөвшөөрөхийг энэ Стандарт шаарддаг. Яагаад гэвэл, хүлээн авагч нь тусгайлан заасны дагуу гуравдагч талд тодорхой бараа, үйлчилгээг нийлүүлэхдээ уг шилжүүлсэн хөрөнгөнд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг зарцуулах, эсвэл ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг тэрхүү шилжүүлэгчид буцаан өгөх шаардлагатай тул тухайн хүлээн авагч нь нөөцийн зарлагын гүйлгээнээс зайлсхийж чадахгүй юм. Нөхцлийн шинж төрлөөс хамааран түүнийг явц өрнөлийн дагуу аажмаар биелүүлж болох юм. Ингэснээр өр төлбөрийн дүнг аажмаар бууруулж, тэр хэмжээгээр орлогоо хүлээн зөвшөөрөх боломжийг тухайн байгууллагад олгодог. Эсвэл ирээдүйн тодорхой үйл явдал гарч тохиолдсон үед зөвхөн түүнийг биелүүлж болох юм. Ингэснээр байгууллага нь уг үйл явдал гарч тохиолдсон үед өр төлбөрийг бууруулж, орлогыг хүлээн зөвшөөрдөг.

ДҮ12. Харин зарим хүмүүс нь нөөцийн орлогын гүйлгээнд хамаарах нөхцөл хангагдахгүй байх нилээд магадлалтай бөгөөд уг ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг тэрхүү шилжүүлэгчид буцаан өгөх

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

шаардлагатай зөвхөн тийм тохиолдолд өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэж үздэг. Хэдийгээр нөхцлийг хангахын тулд нөөцийг зарцуулах шаардлагатай боловч байгууллага нь уг хөрөнгийн хяналтыг анх олж авсан үед түүний нийт бодит үнэ цэнээр орлого гэж хүлээн зөвшөөрөх шаардлагатай болох учраас энэ нь тухайн байгууллага орлогыг хугацаанаас нь өмнө хүлээн зөвшөөрөхөд хүргэх тул УСНББОУСЗ нь энэ саналаас татгалзсан. Иймээс уг шилжүүлгээр хүлээлгэсэн нөхцлийг биелүүлэх эсвэл ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг тухайн шилжүүлэгчид буцаан өгөх одоогийн үүргийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөхгүй.

### **Болзол - Хязгаарлалт**

ДҮ13. Энэ Стандарт нь шилжүүлсэн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед тухайн хязгаарлалттай холбоотойгоор өр төлбөр хүлээн зөвшөөрөхийг байгууллагуудад зөвшөөрдөггүй. Яагаад гэвэл, энэ Стандартад тодорхойлсончлон, хязгаарлалт нь түүнийг биелүүлэхийн тулд ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг зарцуулах одоогийн үүргийг уг хүлээн авагч байгууллагад хүлээлгэдэггүй. Харин хязгаарлалтыг зөрчих нь уг хүлээн авагч байгууллагад торгууль гэх мэт хариуцлагыг эцсийн эцэст хүлээлгэхэд хүргэж болох юм. Гэвч ийм хариуцлага хүлээлгэлт нь тухайн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн бус, харин зөрчлийн улмаас хууль ёсоор хэрэгжүүлэх арга хэмжээний үр дүн байдаг.

### **Арилжааны болон арилжааны бус бүрэлдэхүүн хэсгүүд бүхий ажил гүйлгээ**

ДҮ14. Нэг ажил гүйлгээ нь арилжааны ба арилжааны бус гэсэн хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй байж болно гэдгийг энэ Стандартад тэмдэглэсэн. УСНББОУСЗ-ийн үзэл бодлоор бол энэ тохиолдолд уг ажил гүйлгээний бүрэлдэхүүн хэсгүүдийг ялган тодорхойлж, тус тусад нь хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Бүрэлдэхүүн хэсгүүдийн ялган тодорхойлолт нь санхүүгийн тайлангийн ил тод, ойлгомжтой байдлыг нэмэгдүүлж, ажил гүйлгээг мөн чанараар тайлагнах түүний чанарын шинжүүдийг хангадаг.

### **Эздийн хувь оролцоо**

ДҮ15. Улсын сектор дахь эздийн хувь оролцоог нотлон харуулж болох зарим төрлийн баримтжуулалтын жишээг энэ Стандартад тодорхойлсон байдаг (38-р параграф). Улсын секторын олон байгууллагууд нь тэднийг хянадаг, өмчилдөг эсвэл тэдний гишүүн болох байгууллагуудаас нөөцийн орлогын гүйлгээг хүлээн авдаг. Зарим тохиолдолд нөөцийн орлогын гүйлгээг эздийн хувь оролцоо гэж тодорхойлдог. Нөөцийн орлогын гүйлгээний хэлбэр буюу орлогын гүйлгээний талаархи хяналт тавигч байгууллагын ангиллыг нотлох тийм баримтжуулалт байлаа ч гэсэн эздийн хувь оролцоо гэж ангилах нөөцийн орлогын гүйлгээний хувьд тухайн ажил гүйлгээний мөн чанар нь тэрхүү ангилалтай нийцсэн байх ёстой гэсэн үзэл бодлыг энэ Стандартад тусгадаг.

## Хөрөнгийн хэмжилт

ДҮ16. Энэ Стандарт нь арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн хөрөнгийг тэрхүү олж эзэмшсэн өдрөөрх тэдгээрийн бодит үнэ цэнээр анх хэмжихийг шаарддаг. УСНББОУСЗ-ийн үзэл бодлоор бол энэ нь тухайн ажил гүйлгээний мөн чанар ба хүлээн авагчид түүний үзүүлэх үр дагаврыг тусгахад тохиромжтой байдаг. Арилжааны ажил гүйлгээний хувьд олж эзэмшсэн өртөг нь уг олж эзэмшсэн хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжүүр байдаг. Гэвч арилжааны бус ажил гүйлгээний хувьд тодорхойлолт ёсоор, хөрөнгийг олж эзэмшихийн тулд өгсөн төлбөр нь уг олж эзэмшсэн хөрөнгийн бодит үнэ цэнэтэй ойролцоогоор тэнцүү биш байдаг. Бодит үнэ цэнэ нь тухайн ажил гүйлгээний үр дүнд улсын секторын байгууллагад хуримтлагдан орох жинхэнэ үнэ цэнийг хамгийн үнэн зөв тусган илэрхийлдэг. Арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн хөрөнгийн хувьд түүний бодит үнэ цэнээр хийх анхны хэмжилт нь үнэгүй буюу нэрлэсэн өртгөөр олж эзэмшсэн хөрөнгийн хувьд УСНББОУС 16, *Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө* ба УСНББОУС 17, *Үндсэн Хөрөнгө*-д баримталсан хандлагатай нийцдэг. Энэхүү Стандартын шаардлагуудтай бүрэн нийцүүлэхийн тулд УСНББОУСЗ нь УСНББОУС 12, *Бараа Материал*, УСНББОУС 16, УСНББОУС 17-д дагалдах нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан.

## Байгууллагын банкны харилцах данс

ДҮ17. Байгууллагын банкны харилцах дансанд байршуулсан бүх мөнгө нь хөрөнгийн тодорхойлолтыг хангах бөгөөд уг байгууллагын хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг биелүүлнэ гэсэн шаардлагыг энэ Стандартад харгалзан үзсэн. УСНББОУСЗ нь Мөнгөн суурьт УСНББОУС, *Нягтлан Бодох Бүртгэлийн Мөнгөн Суурийн Дагуух Санхүүгийн Тайлагнал*-ын 1.2.6 ба 1.2.7-р параграфуудад энэ зарчмыг тусган оруулсан. Тайлагнагч байгууллага нь бусад байгууллагын агентын үүрэг гүйцэтгэх явцад цуглуулсан ба өөрийн банкны харилцах дансанд байршуулсан аливаа дүнгийн хувьд өр төлбөр хүлээн зөвшөөрөхийг энэхүү Стандартаар шаарддаг.

## Өр төлбөрийн хэмжилт

ДҮ18. Байгууллага нь нөөцийн орлогын гүйлгээний хувьд өр төлбөр хүлээн зөвшөөрдөг тохиолдолд уг үүргийг барагдуулахад шаардлагатай дүнгийн тухайн тайлангийн өдрөөрх хамгийн сайн тооцооллоор тэрхүү өр төлбөрийг анх хэмжихийг энэ Стандартаар шаарддаг. Энэхүү хэмжилтийн суурь нь УСНББОУС 19-тэй нийцдэг. УСНББОУСЗ нь УСНББОУС 19-ийн суурь үндэслэл болсон НББОУС 37-гийн санал болгосон нэмэлт өөрчлөлтүүдийг (*Санхүүгийн Бус Өр Төлбөр* гэж өөрчлөн нэрлэх) бас мэдэж байсан бөгөөд НББОУС 37-гийн аливаа өөрчлөлт, боловсронгуй болголтын хариу болгон түүнийг хянан үнэлэх ба зохих ёсоор харгалзан үзэх юм.

### **Татвар ногдох үйл явдал**

ДҮ19. Татвар ногдох үйл явдлыг энэ Стандарт нь засгийн газар, хууль тогтоогч байгууллага буюу бусад эрх бүхий этгээдээс татвар ногдох зүйл гэж тогтоосон, өнгөрсөн үйл явдал гэж тодорхойлсон. Энэ нь татвар ногдуулах ажил гүйлгээнээс үүсэх хөрөнгө ба орлогыг хүлээн зөвшөөрөх боломжит хамгийн эхний хугацаа бөгөөд тухайн хөрөнгийн хяналтыг бий болгох уг өнгөрсөн үйл явдал гарч тохиолдох агшин гэдгийг энэ Стандартад тэмдэглэсэн. Тэдгээр нөөцийг хүлээн авах үедээ байгууллага нь татвар ногдуулалтаас үүсэх нөөцийн хяналтыг зөвхөн олж авч байна гэсэн хувилбар үзэл баримтлалыг УСНББОУСЗ нь харгалзан үзсэн. УСНББОУСЗ нь зарим татварын гүйлгээг найдвартай хэмжихэд хүндрэлтэй гэдгийг хүлээн зөвшөөрдөг боловч ийм хандлага нь санхүүгийн тайлагналын аккруэл суурийн хувьд тохиромжгүй гэж үзсэнээр уг хувилбар үзэл баримтлалаас татгалзсан.

### **Урьдчилж орсон орлого**

ДҮ20. Татвар ногдох үйл явдал гарч тохиолдох эсвэл шилжүүлгийн хэлцэл нь хууль ёсны хүчин төгөлдөр болохоос өмнө нөөцийг урьдчилан хүлээн авдаг байгууллага нь үүнтэй ижил дүнгээр хөрөнгө ба өр төлбөр хүлээн зөвшөөрөхийг энэхүү Стандартаар шаарддаг. Энэ нь орлогыг үүсгэх суурь үйл явдал гарч тохиолдсон тухайн тайлант үед орлогыг хүлээн зөвшөөрөх аккруэл нягтлан бодох бүртгэлийн зарчимтай нийцнэ. Татвар ногдох үйл явдал гарч тохиолдоогүй эсвэл шилжүүлгийн гэрээ нь хууль ёсны хүчин төгөлдөр болоогүй тохиолдолд байгууллага нь тухайн авсан нөөцийн бүх буюу зарим хэсгийг буцаан өгөх шаардлагатай байж болох юм. Татвар ногдох үйл явдлаас өмнө нөөцийг урьдчилан хүлээн авсан бол байгууллага нь дараагийн тайлант үед нөөцийг зарцуулах нилээд магадлалтай гэж үзсэн зөвхөн тийм тохиолдолд өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэж зарим хүмүүс үздэг. Татвар ногдох үйл явдал гарч тохиолдох хүртэл орлогыг хүлээн зөвшөөрөхгүй гэсэн үзэл баримтлалыг УСНББОУСЗ нь дэмждэг бөгөөд шилжүүлгийн гэрээ нь заавал биелүүлэх гэрээ болохоос өмнө нөөцийг хүлээн авсан тохиолдолд тухайн байгууллага нь уг урьдчилж орсон орлогын хувьд хөрөнгө, өр төлбөр хүлээн зөвшөөрдөг болгохын тулд энэхүү зарчмыг шилжүүлэгт өргөжүүлэн хэрэглэсэн.

### **Татварын системээр дамжуулан төлсөн зардал ба татварын зарлага**

ДҮ21. Энэхүү Стандарт нь татварын системээр дамжуулан төлсөн зардлыг татварын зарлагаас ялган тодорхойлох ба нийтлэг зорилготой санхүүгийн тайланд татварын зарлагыг орлогоос тусад нь хүлээн зөвшөөрөхийг шаарддаг. Яагаад гэвэл, энэ Стандартад тодорхойлсончлон, татварын системээр дамжуулан төлсөн зардал нь зардлын тодорхойлолтыг хангадаг бөгөөд УСНББОУС 1-д заасан зарчмын дагуу зардлыг орлогоос суутган тооцож, цэвэр дүн гаргахыг зөвшөөрдөггүй. Энэ Стандартад тодорхойлсончлон, татварын зарлага нь хүлээн авсан буюу авах татварын орлогын дүнг тодорхойлоход ашигладаг олон хүчин зүйлсийн

нэг бөгөөд түүнийг орлогоос тусад нь хүлээн зөвшөөрдөггүй. УСНББОУСЗ-ийн үзэл бодлоор бол ийм арга хандлага нь энэхүү Стандартад тогтоосон зарчмуудтай нийцэх юм.

- ДҮ22. Татварын системээр дамжуулан төлсөн зардлын хувьд энэ Стандартад тодорхойлсон арга хандлага нь өөрийн гишүүн орнуудын статистикийн тайланд зориулан Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа ба Хөгжлийн Байгууллагаас (ЭЗХАХБ) одоогоор тогтоосон арга хандлагаас өөр юм. ЭЗХАХБ нь хувь хүн татвар төлөгчдийн татварын өр төлбөрийг тэг болтол буурах хүртэл уг татварын системээр төлж буй зардлыг (буюу хүчингүй болгохгүй татварын хөнгөлөлтийг) хассан цэвэр дүнгээр татварын орлогыг харуулах, харин тэг болсон тохиолдолд татвар төлөгчдөд төлсөн төлбөрийг зардал гэж харуулахыг одоогоор шаардаж байна.<sup>2</sup> УСНББОУСЗ-ийн үзэл бодлоор бол, ЭЗХАХБ-ын одоогийн арга хандлага нь УСНББОУС-ын суурь үндэслэл болох онолын зарчмууд, түүнчлэн орлого ба зардлын зүйлсийг харилцан суутгаж, цэвэр дүн гаргахгүй байх УСНББОУС 1-ийн шаардлагатай нийцдэггүй. Статистикийн санхүүгийн тайлагналын үзэл баримтлалыг одоо хянан үзэж байна. Ялангуяа, Нэгдсэн Үндэсний Байгууллагын *Үндэсний Тооцооны Системийн* шинэ хэвлэлийг одоогоор боловсруулж байгаа бөгөөд 2008 онд хэвлэн нийтлэх юм. Уг хянан засварласан үзэл баримтлал нь татварын хөнгөлөлтийн талаархи одоогийн тайлагналын шаардлагуудыг өөрчлөн засварлаж болох юм. *Үндэсний Тооцооны Системийн* хянан засварлалт нь статистикийн бусад үзэл баримтлалын хянан засварлалтаас ямагт түрүүлж хийгдэж байдаг.

### **Татварын цоорхой**

- ДҮ23. Зарим татварын хувьд татварын хуулийн дагуу засгийн газрын цуглуулах эрхтэй дүн нь цуглуулагдах дүнгээс өндөр гэдгийг тайлагнагч байгууллагууд мэддэг боловч уг зөрүүгийн дүнг найдвартай хэмжиж чаддаггүй. Цуглуулсан дүн нь далд эдийн засаг (буюу хар зах), зальт ажиллагаа, татвараас зайлсхийлт, татварын хуулийн үл даган мөрдөлт, алдаа зэргийн улмаас бага байдаг. Хуулийн дагуу авах ёстой дүн ба засгийн газрын цуглуулж чадах дүнгийн хоорондох зөрүүг “татварын цоорхой” гэж нэрлэдэг. Үл цуглуулагдах гэж тодорхойлон татварын орлогод өмнө нь тусгасан дүнгүүд нь татварын цоорхойны нэг хэсэг биш юм.
- ДҮ24. Татварын цоорхойны хэмжээгээр засгийн газарт тийм хэмжээний нөөц орно гэж хүлээхгүй тул татварын цоорхой нь хөрөнгийн тодорхойлолтыг хангахгүй гэж УСНББОУСЗ үздэг. Иймээс татварын цоорхойны хувьд хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлыг хүлээн зөвшөөрөхгүй.

### **Хариу төлбөргүй үйлчилгээ**

- ДҮ25. Энэ Сандарт нь хариу төлбөргүй үйлчилгээг хүлээн зөвшөөрөхийг зөвшөөрдөг боловч заавал шаарддаггүй. Хариу төлбөргүй олон үйлчилгээ

---

<sup>2</sup> ЭЗХАХБ, Орлогын Статистик (Парис: ЭЗХАХБ, 2000 он): хуудас 267, зүйл 20-21.

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

нь хөрөнгийн тодорхойлолтыг хангадаг бөгөөд зарчмын хувьд түүнийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэсэн үзэл бодлыг энэ Стандартад баримталдаг. Гэвч ийм тохиолдолд найдвартай хэмжилт хийхэд хүндрэлтэй байж болох юм. Өөр зарим тохиолдолд, тайлагнагч байгууллага нь тухайн үзүүлсэн үйлчилгээний хувьд хангалттай хяналттай байдаггүй учраас хариу төлбөргүй үйлчилгээ нь хөрөнгийн тодорхойлолтыг хангахгүй. Хэмжилт ба хяналттай холбоотой хүндрэлтэй байдлын улмаас хариу төлбөргүй үйлчилгээг хүлээн зөвшөөрөхийг УСНББОУСЗ нь зөвшөөрөх боловч заавал шаардах хэрэггүй гэсэн дүгнэлтэнд хүрсэн.

**Нийгмийн хамгааллын хөтөлбөрт оруулах албан журмын шимтгэл**

ДҮ26. Энэ Стандарт нь арилжааны бус ажил гүйлгээ болох нийгмийн хамгааллын хөтөлбөрт төлөх албан журмын шимтгэлийг өөрийн цар хүрээнээс хасаагүй. Улс орон бүрд нийгмийн хамгааллын хөтөлбөрөө санхүүжүүлэх янз бүрийн олон арга хэмжээнүүд байдаг. Нийгмийн хамгааллын хөтөлбөрт албан журмаар төлөх шимтгэл нь арилжааны эсвэл арилжааны бус ажил гүйлгээ болох эсэх нь тухайн хөтөлбөрийн тодорхой арга хэмжээнүүдээс хамаардаг бөгөөд уг нийгмийн хамгааллын хөтөлбөрт төлсөн шимтгэлийг энэ Стандартад заасан зарчмуудын дагуу, эсвэл ийм хөтөлбөрийг зохицуулдаг олон улсын буюу үндэсний бусад стандартуудад заасан зарчмуудын дагуу хүлээн зөвшөөрөх эсэхийг тодорхойлохдоо мэргэжлийн шүүн тунгаалт хийдэг.

**2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУСЗ-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 23-д хийсэн хянан засварлалт**

ДҮ27. УСНББОУСЗ нь 2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (а) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р* параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

## **Хэрэгжүүлэх заавар удирдамж**

*Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 23-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### **Арилжааны бус ажил гүйлгээний орлогын хэмжилт, хүлээн зөвшөөрөлт ба тодруулга**

*Орлогын татвар (65-р параграф)*

ХЗУ1. Үндэсний засгийн газар (тайлагнагч байгууллага) нь тухайн улсад олсон хувь хүний орлогод 25 хувиар татвар ногдуулдаг. Цалингаас уг татварыг суутгаж, суутгасан татвараа сар бүр шилжүүлэхийг ажил олгогчдоос шаарддаг. Цалингаас бусад (жишээлбэл; хөрөнгө оруулалтын) мэдэгдэхүйц орлоготой хувь хүмүүс нь тооцоолсон татвараа улирал тутам төлөхийг тэднээс шаарддаг. Түүнчлэн, хувь хүмүүс нь татварын жилийн (календарийн жилийн) дараагийн жилийн 4 дүгээр сарын 15-ны дотор татварын албанд татварын тайлангаа тушаах ба төлөх үлдсэн татвараа мөн өдрөөр төлөх (эсвэл илүү төлөлтөө буцаан авахаар нэхэмжлэх) ёстой. Засгийн газрын тайлант хугацаа нь 6 дугаар сарын 30-нд дуусгавар болдог.

ХЗУ2. Татвар төлөгч нь татвар ногдох орлого олсон, өөрөөр хэлбэл татвар ногдох үйл явдал гарч тохиолдсон үед засгийн газар нь орлогын татварын авлага болох нөөцийг хяналтандаа авдаг. Тухайн тайлант үеийн туршид олсон орлогод ногдох хувь хүний орлогын албан татварын хувьд засгийн газар нь түүнийг найдвартай хэмжиж чадах хэмжээгээр хөрөнгө ба орлогыг уг тайлант үеийн эцэст хүлээн зөвшөөрнө. Өмнөх тайлант үеүдэд олсон боловч энэ тайлант үе болох хүртэл хөрөнгийн тодорхойлолтыг хангаагүй буюу хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг биелүүлээгүй байсан орлогод ногдуулах татварын хувьд хөрөнгө ба орлогыг мөн хүлээн зөвшөөрнө.

*Татварын орлогын хэмжилт (67-70-р параграф)*

ХЗУ3. Үндэсний засгийн газар (тайлагнагч байгууллага) нь өөрийн улс орны хүрээнд орлого олж буй бүх хүмүүсийн хувь хүний орлогод албан татвар ногдуулдаг. Уг татварыг одоогийн тайлант үеэс дал гаруй жилийн өмнөөс анх ногдуулж эхэлсэн бөгөөд нийт далан жилийн хугацааны татварын статистик мэдээ байдаг. Татварын жил болон тайлант үе нь 01 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 31-ний хооронд байдаг. Татвар төлөгч нь жил бүрийн 4 дүгээр 30-ны дотор татварын тайлангаа тушаах ба аливаа татварын үлдэгдлийг 6 дугаар сарын 30-ны дотор төлөх ёстой. Засгийн газар нь аудит хийлгэсэн нийтлэг зорилготой, нэгтгэсэн санхүүгийн тайлангаа хууль тогтоогч байгууллагад 3 дугаар сарын 31-ний дотор танилцуулахыг хуулиар шаардсан байдаг.

ХЗУ4. Орлогын татварын орлогыг татвар ногдох үйл явдал гарч тохиолдсон, өөрөөр хэлбэл, татвар ногдох орлогыг олсон тухайн тайлант үед хүлээн



АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

зөвшөөрөх хэрэгтэй. Өөрийн нийтлэг зорилготой санхүүгийн тайлангаа гаргах хүртэл засгийн газар нь орлогын татварын авлагаа шууд хэмжих боломжийг уг татварын удирдлагын системээр олгодоггүй учраас засгийн газар нь орлогын татварын орлогод хамаарах авлагаа шууд бусаар хэмжихийн тулд загвар боловсруулдаг. Засгийн газар нь уг татварын статистик мэдээлэл дэх орлогын татвар цуглуулалтын талаархи түүхийг ашигладаг бөгөөд найдвартай загвар боловсруулахын тулд ажиглаж болох бусад юмс үзэгдлүүдтэй түүнийг зэрэгцүүлэн үздэг. Уг бусад юмс үзэгдэлд дотоодын нийт бүтээгдэхүүн гэх мэт эдийн засгийн бусад статистик мэдээлэл, ажил олгогчийн суутган тооцсон орлогын татварын хэсэгчилсэн төлбөр, борлуулалтын татварын цуглуулалт (хэрэв ийм татварыг ногдуулдаг бол) гэх мэт санхүүгийн үзэгдлүүд, төв банкны гаргадаг банкны статистик мэдээлэл хамаарна. Засгийн газар нь ийм загварыг боловсруулахдаа эконометрикчийн туслалцааг авч болох бөгөөд тухайн загварын хэрэгжих боломжит байдлыг олон улсын болон үндэсний аудитын стандартын дагуу гаднын аудиторроор шалгуулж болох юм.

ХЗУ5. Энэхүү загвар нь тайлант үеийн туршид уг тайлагнагч байгууллагад хуримтлагдан бий болсон хөрөнгө, орлогыг найдвартай хэмжих, улмаар нийтлэг зорилготой санхүүгийн тайландаа түүнийг хүлээн зөвшөөрч, тодруулах боломжийг тухайн байгууллагад олгодог. Орлогын татварын орлогын нягтлан бодох бүртгэлийн бодлого, үүн дотроо хэмжилтийн суурийг нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн тодруулга хэсэгт тодруулна. Зарим тохиолдолд нэг тайлант үеийн татварын орлогын тооцооллыг дараагийн тайлант үед засварлаж болох юм. Тооцооллын өөрчлөлтийг УСНББОУС 3-ын дагуу гүйцээх горимоор хүлээн зөвшөөрнө.

*Нэмэгдсэн өртгийн албан татвар (65-р параграф)<sup>3</sup>*

ХЗУ6. Үндэсний засгийн газар (тайлагнагч байгууллага) нь бүх аж ахуйн нэгжид нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) ногдуулдаг. Татвар нь нэмэгдсэн өртгийн 15 хувь байдаг бөгөөд борлуулалт хийх үедээ борлуулагч нь худалдан авагчдаас (татвар төлөгчдөөс) цуглуулж авдаг. Том болон дунд хэмжээний аж ахуйн нэгжүүд нь нэмэгдсэн өртгийн албан татварын тайланг 7 хоног тутам татварын албанд цахим хэлбэрээр илгээх шаардлагатай байдаг. Харин жижиг аж ахуйн нэгжүүд нь НӨАТ-ын тайланг улирал тутам цаасаар тушаахыг зөвшөөрдөг.

ХЗУ7. Татвар ногдох үйл явдал гарч тохиолдсон буюу татвар ногдох үйл ажиллагаа хийгдсэн, өөрөөр хэлбэл, нэмэгдсэн өртөг бүхий бараа, үйлчилгээг тухайн тайлант үеийн туршид борлуулсан тохиолдолд засгийн газар нь НӨАТ-ын авлага болох нөөцөнд хяналт тогтоодог. Засгийн газар нь татвар ногдох үйл ажиллагаа хийгдсэн тайлант үед эсвэл үүний дараа тухайн татварын авлагыг найдвартай хэмжиж чадахаар болсон үед хөрөнгө ба орлогыг нийтлэг зорилготой санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрдөг. Олон тохиолдолд татварын тайлангийн хугацаа нь тухайн

---

<sup>3</sup> Зарим улс орон нь Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар (НӨАТ) ба Бараа, Үйлчилгээний Татвар (БҮТ) нэр томъёог харилцан ижил утгатайгаар хэрэглэдэг.

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

тайлант үетэй давхцдаггүй байж болно. Энэ тохиолдолд тухайн тайлант үеийн татварын орлогын тооцооллыг дараагийн тайлант үед хянан засварлаж болох юм. Тооцооллын өөрчлөлтийг УСНББОУС 3-ын дагуу гүйцээх горимоор хүлээн зөвшөөрдөг.

*Бараа, үйлчилгээний татвар (65-р параграф)*

ХЗУ8. Үндэсний засгийн газар (тайлагнагч байгууллага) нь бараа, үйлчилгээний борлуулалтанд бараа, үйлчилгээний татвар (БҮТ)-ыг ногдуулдаг. Уг татвар нь борлуулсан бараа, үйлчилгээний үнэ цэнийн 10 хувь байдаг. Бараа, үйлчилгээний ихэнх борлуулагч нар нь БҮТ-ын тайланг 7 хоног тутам татварын албанд цахим хэлбэрээр илгээх шаардлагатай байдаг. Харин жижиг аж ахуйн нэгжүүд нь БҮТ-ын тайланг улирал тутам цаасаар тушаахыг зөвшөөрдөг.

ХЗУ9. Татвар ногдох үйл явдал гарч тохиолдсон буюу тухайн тайлант үеийн туршид татвар ногдох бараа, үйлчилгээг борлуулсан тохиолдолд засгийн газар нь БҮТ-ын авлага болох нөөцөнд хяналт тогтоодог. Засгийн газар нь борлуулалт ба худалдан авалт хийгдсэн тайлант үед, хэрэв тухайн тайлант үеийн эцэст татварын авлагыг найдвартай хэмжиж чадахгүй бол үүний дараа, уг татварын авлагыг найдвартай хэмжиж чадахаар болмогц хөрөнгө ба орлогыг нийтлэг зорилготой санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрдөг.

*Гаалийн татвар (65-р параграф)*

ХЗУ10. Үндэсний засгийн газар (тайлагнагч байгууллага) нь барааны бүх импортонд гаалийн татвар ногдуулдаг. Гаалийн татвар нь импортолсон барааны төрлөөс хамааран өөр өөр байдаг бөгөөд дотооддоо үйлдвэрлэсэн бараа нь жижиглэн худалдаалах зах зээл арай хямд байхуйц хэмжээгээр уг татварыг тогтоодог. Импортлогч нь гаалийн татварыг төлөх хүртэл тухайн импортолсон барааг гаалийн баталгаат агуулахад хадгалдаг. Импортлогч нь гаалийн байгууллагад импортын мэдүүлэг гаргах бөгөөд гаалийн татварыг тэр даруй төлөх шаардлагатай байдаг. Ихэнх импортлогч нь бараа ирэхээс өмнө мэдүүлгийг цахим хэлбэрээр танилцуулж, барааг усан онгоц буюу нисэх онгоцноос буулгах эсвэл галт тэрэг буюу ачааны машин нь гаалийн хилээр нэвтрэх үед төлбөрийг гаалийн байгууллагад цахим хэлбэрээр шилжүүлдэг.

ХЗУ11. Татвар ногдох үйл явдал гарч тохиолдсон буюу барааг гаалийн хилээр нэвтрүүлэх үед засгийн газар нь гаалийн татварын авлага болох нөөцөнд хяналт тогтоодог. Барааг гаалийн хилээр нэвтрүүлсэн тухайн тайлант үед эсвэл үүний дараа, уг гаалийн татварын авлагыг найдвартай хэмжиж чадахаар болмогц засгийн газар нь хөрөнгө ба орлогыг нийтлэг зорилготой санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрдөг.

*Нас баралтын татвар (65-р параграф)*

ХЗУ12. Үндэсний засгийн газар (тайлагнагч байгууллага) нь 500,000 тоолох нэгж (ТН)-ээс илүү үнэ цэнэтэй бүх өв хөрөнгөнд 40 хувиар нас баралтын

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

татварыг ногдуулдаг. Бүх нас баралтын талаар татварын албанд мэдэгдэхийг эмнэлгийн ажилтнууд болон оршуулгын товчооны захирлуудаас шаарддаг. Үүний дараа үнэлгээчин нь татвар төлөх эсэхийг тодорхойлохын тулд тухайн өв хөрөнгийн хувьд завсрын хугацааны үнэлгээг хийдэг. Гэрээслэлийг биелүүлэгч нь өв хөрөнгийн үнэ цэнийг харуулсан тухайн өв хөрөнгийн жагсаалтыг татварын албанд танилцуулах ба өв хөрөнгөөс төлөх татварыг тодорхойлохыг түүнээс шаарддаг. Бүх татварыг төлөх хүртэл гэрээслэлийг баталгаажуулдаггүй. Гэрээслэлийн хуулийн нарийн төвөгтэй байдал ба үнэлгээний талаархи байнгын маргааны улмаас гэрээсэлэн хөрөнгийг барагдуулж, төлөх татварыг цуглуулах хүртэл дундажаар дөрвөн жилийн хугацаа шаарддаг.

ХЗУ13. Татвар ногдох үйл явдал гарч тохиолдсон буюу татвар ногдох өв хөрөнгийг өмчлөгч хүн нас барсан тохиолдолд засгийн газар нь нас баралтын татварын авлага болох нөөцөнд хяналт тогтоодог. Засгийн газар нь тухайн хүн нас барсан тайлант үед, эсвэл үүний дараа уг хөрөнгийг найдвартай хэмжиж чадахуйц болмогц хөрөнгө ба орлогыг нийтлэг зорилготой санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрдөг.

*Үл хөдлөх хөрөнгийн татвар (65-р параграф)*

ХЗУ14. Орон нутгийн засаг захиргаа (тайлагнагч байгууллага) нь өөрийн нутаг дэвсгэрийн хүрээн дэх бүх үл хөдлөх хөрөнгийн үнэлсэн дүнгийн нэг хувиар татвар ногдуулдаг. Засгийн газрын тайлант үе нь 7 дугаар сарын 01-нээс 6 дугаар сарын 30 байдаг. Үл хөрөнгийн эздэд 7 дугаар сард илгээх татварын ногдуулалтын мэдэгдлээр уг татварыг 7 дугаар сарын 31-нд ногдуулдаг бөгөөд 8 дугаар 31-ний дотор татварыг төлөх ёстой. Хэрэв татварыг уг өдөр төлөхгүй бол үл хөдлөх хөрөнгийн эздэд нь төлөөгүй татварын дүнгээс сарын 3 хувиар тооцож, алданги төлнө. Засгийн газар нь төлөгдөөгүй татварыг барагдуулахын тулд үл хөдлөх хөрөнгийг хурааж, борлуулахыг татварын хуулиар зөвшөөрсөн байдаг.

ХЗУ15. Татвар ногдох үйл явдал гарч тохиолдсон буюу татварыг ногдуулах хугацаа, өөрөөр хэлбэл 7 дугаар сарын 31 болсон тохиолдолд засгийн газар нь үл хөдлөх хөрөнгийн татварын авлага болох нөөцөнд хяналт тогтоодог. Засгийн газар нь уг өдөр болох тухайн тайлант үеийн нийтлэг зорилготой санхүүгийн тайланд хөрөнгө ба орлогыг хүлээн зөвшөөрдөг.

*Орлогын татварын урьдчилж орсон орлого (66-р параграф)*

ХЗУ16. “А” засгийн газар (тайлагнагч байгууллага) нь өөрийн нутаг дэвсгэрийн хүрээнд бүх иргэдэд орлогын татвар ногдуулдаг. Татварын жил болон тайлант үе нь 01 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 31-ний хооронд байдаг. Хувиараа хөдөлмөр эрхэлж буй татвар төлөгч нь татварын жил эхлэхийн яг өмнөх жилийн 12 дугаар сарын 24-нөөр тухайн жилийн орлогын татварыг тооцоолж, төлөх шаардлагатай байдаг. Хэрэв татвар төлөгч нь төлөх татварын дүн арай бага байх талаархи тайлбараа 12 дугаар сарын 31-нээс өмнө ирүүлээгүй бол хамгийн сүүлийн байдлаарх татварын ногдуулалтын хувьд төлөх дүн дээр 10 хувийг нэмж, татварын

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

тооцоолол хийхээр татварын хуульд заасан байдаг (татвар төлөгчийн тайлагнан тооцсон татвар нь уг эцсийн төлөх ёстой дүнгээс материаллагаар бага байсан гэдэг батлагдвал торгууль ногдуулдаг). Хувиараа хөдөлмөр эрхлэгч татвар төлөгч нь тухайн татварын тайлант жилийн эцсээс хойш өөрийн татварын тайланг танилцуулж, илүү төлсөн татвараа засгийн газраас буцаан авна эсвэл дутуу татвараа төлнө.

ХЗУ17. Хувиараа хөдөлмөр эрхлэгч татвар төлөгчдөөс 12 дугаар сарын 24-ний байдлаар хүлээн авсан нөөц нь дараа жил төлөх татварт хамаарах урьдчилж орсон орлого юм. Татвар ногдох үйл явдал нь одоогоор хараахан эхлээгүй байгаа татварын тайлант үед орлого олох үйл явц юм. Тайлагнагч байгууллага нь хөрөнгийн (банкин дахь мөнгөний) өсөлт ба өр төлбөрийн (урьдчилж орсон орлогын) өсөлтийг хүлээн зөвшөөрнө.

*Засгийн газрын бусад түвшинд нийтлэг зориулалтаар олгосон буцалтгүй тусламж (14-16 ба 76-р параграф)*

ХЗУ18. Үндэсний засгийн газар (шилжүүлэгч) нь нийгэм эдийн засгийн хоцрогдсон бүс нутгийн орон нутгийн засаг захиргаанд 10 сая ТН-ийн буцалтгүй тусламж олгосон. Орон нутгийн засаг захиргаа (тайлагнагч байгууллага) нь өөрийн Үндсэн хуулийн дагуу нийгмийн янз бүрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ёстой; гэвч тусламж дэмжлэггүйгээр эдгээр бүх хөтөлбөрийг хэрэгжүүлэх хангалттай нөөцгүй байна. Уг буцалтгүй тусламжинд ямар нэг болзол тавиагүй. Орон нутгийн бүх засаг захиргаа нь аудитласан нийтлэг зорилготой санхүүгийн тайланг бэлтгэж, толилуулахыг түүнээс шаарддаг.

ХЗУ19. Энэхүү буцалтгүй тусламжинд ямар нэг болзол тавиагүй, гүйцэтгэлийн үүрэг хүлээлгээгүй учраас орон нутгийн засаг захиргаа нь уг буцалтгүй тусламжийг хүлээн авсан буюу хүлээн авахаар болсон тайлант үеийн нийтлэг зорилготой санхүүгийн тайланд тэрхүү шилжүүлгийг хөрөнгө ба орлого гэж хүлээн зөвшөөрнө.

*Нөхцлийн тодорхойлолтыг үл хангах болзол бүхий шилжүүлэг (20-25-р параграф)*

ХЗУ20. Үндэсний засгийн газар нь мужийн засгийн газрын нийтийн аж ахуйн байгууллагад 50 сая ТН-ийн мөнгөн шилжүүлгийг дараах нөхцөлтэйгээр олгосон:

- (а) Нийтийн аж ахуйн хөрөнгийг аливаа бусад төлөвлөсөн өсөлтөөс гадна нэмэлт 1,000 нэгжээр нэмэгдүүлэх;
- (б) Өөрийн нийтийн аж ахуйн нэгжийн зорилтуудад дэмжлэг үзүүлэхийн тулд уг мөнгөн шилжүүлгийг бусад арга замаар ашиглах.

Хэрэв эдгээр болзлын аль нэг нь хангагдахгүй бол хүлээн авагч байгууллага нь уг мөнгийг үндэсний засгийн газарт буцаан өгөх ёстой.

ХЗУ21. Мужийн засгийн газрын нийтийн аж ахуйн байгууллага нь 50 сая ТН-ээр хөрөнгө (мөнгө) ба орлогын өсөлтийг хүлээн зөвшөөрнө. Хүлээн авагчид гүйцэтгэлийн үүрэг хүлээлгэхгүй тийм байдлаар болзлыг уг шилжүүлгийн

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

гэрээнд ерөнхий заасан - Шилжүүлгийн нөхцлөөр биш, харин тухайн байгууллагын үйл ажиллагааны бүрэн эрхээр гүйцэтгэлийн үүргийг хүлээлгэдэг.

*Улсын их сургуульд хязгаарлалттайгаар олгосон шилжүүлэг (19 ба 76-р параграф)*

ХЗУ22. Үндэсний Засгийн газар (шилжүүлэгч) нь их сургуулийн хотхон байгуулахад зориулан тус их сургууль (тайлагнагч байгууллага)-д 200 га газрыг том хотод шилжүүлэн өгсөн. Уг газрыг их сургуулийн хотхоны зориулалтаар ашиглана гэж тэрхүү шилжүүлгийн гэрээнд заасан боловч хэрэв ийм зорилгоор ашиглахгүй бол буцаан өгөх талаар тус гэрээнд заагаагүй.

ХЗУ23. Их сургууль нь уг газрын хяналтыг олж авсан тухайн тайлант үеийн санхүүгийн байдлын тайландаа тэрхүү газрыг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө. Уг газрыг УСНББОУС 17-гийн дагуу түүний бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Энэхүү хязгаарлалт нь өр төлбөрийн тодорхойлолтыг хангахгүй буюу өр төлбөр гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг биелүүлэхгүй байна. Иймээс тус их сургууль нь уг газрыг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн тайлант үеийн санхүүгийн үр дүнгийн тайландаа газрын хувьд орлогыг хүлээн зөвшөөрнө.

*Засгийн газрын бусад түвшинд нөхцөлтэйгээр олгосон буцалтгүй тусламж (17-18-р параграф)*

ХЗУ24. Үндэсний засгийн газар (шилжүүлэгч) нь нийтийн тээврийн системийг засаж сайжруулахад зориулан 10 сая ТН-ийн буцалтгүй тусламжийг хөдөө орон нутгийн засаг захиргаанд (тайлагнагч байгууллагад) олгосон. Уг мөнгийг дараах байдлаар ашиглахыг тусгайлан заасан. Үүнд: мөнгөний 40 хувийг одоогийн төмөр зам болон трамвайн системийг сайжруулахад, 40 хувийг шинэ төмөр зам буюу трамвайн системийг барьж байгуулахад, 20 хувийг бараа материал дугуй худалдан авах ба сайжруулахад зориулан ашиглана. Буцалтгүй тусламжийн нөхцлийн дагуу уг мөнгийг зөвхөн болзолд зааснаар ашиглах бөгөөд уг хөдөө орон нутгийн засаг захиргаа нь буцалтгүй тусламжийн мөнгийг хэрхэн зарцуулсан талаархи дэлгэрэнгүй тодруулгыг өөрийн аудитласан, нийтлэг зорилготой санхүүгийн тайланд тусгах шаардлагатай. Буцалтгүй тусламжийг тусгайлан заасны дагуу тухайн тайлант жилд зарцуулах эсвэл үндэсний засгийн газарт буцаан өгөхийг уг буцалтгүй тусламжийн гэрээгээр шаарддаг.

ХЗУ25. Хөдөө орон нутгийн засаг захиргаа нь буцалтгүй тусламжийн мөнгийг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө. Буцалтгүй тусламжинд хамаарах нөхцлийн дагуу тус хөдөө орон нутгийн засаг захиргаа нь мөн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Тус хөдөө орон нутгийн засаг захиргаа нь нөхцлийг биелүүлснээр, өөрөөр хэлбэл зөвшөөрөгдсөн зардлага гаргаснаар өр төлбөрийг бууруулах бөгөөд тэрхүү өр төлбөрийг

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

барагдуулсан тухайн тайлант үеийн санхүүгийн үр дүнгийн тайланд орлогыг хүлээн зөвшөөрнө.

*Судалгааны буцалтгүй тусламж (мөн чанарын хувьд арилжааны ажил гүйлгээ)  
(8-р параграф)*

ХЗУ26. Цэвэрлэгээний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг томоохон корпораци (шилжүүлэгч) нь толбо хурдан арилгадаг зарим химийн бодисын үр дүнтэй байдлын талаар судалгаа хийлгэхийн тулд улсын их сургууль (тайлагнагч байгууллага)-д мөнгө өгсөн. Корпораци нь олон нийтэд зарлан мэдэгдэхээс өмнө судалгааны үр дүнг тэдэнтэй хуваалцах ба уг химийн бодисын хувьд өөрөө патентын эрхийг авах болзол заасан.

ХЗУ27. Энэ нь арилжааны ажил гүйлгээ юм. Буцалтгүй тусламжийн хариуд их сургууль нь судалгааны үйлчилгээ үзүүлж, судалгааны үр дүнгээс ашиг олох эрх болох биет бус хөрөнгө (ирээдүйн эдийн засгийн үр өгөөж)-ийг түүнд өгч байна. Энэ ажил гүйлгээний хувьд УСНББОУС 9 ба УСНББОУС 31, *Биет Бус Хөрөнгө*-ийг мөрдөнө.

*Өрөөс чөлөөлөлт (84-87-р параграф)*

ХЗУ28. Үндэсний засгийн газар (шилжүүлэгч) нь ус цэвэрлэх байгууламж барихад зориулж, орон нутгийн засаг захиргаанд (тайлагнагч байгууллага) 20 сая ТН зээлдүүлсэн. Бодлогын өөрчлөлтийн дараа тус үндэсний засгийн газар нь зээлээс чөлөөлөхөөр шийдвэрлэсэн. Зээлээс чөлөөлөхтэй холбоотойгоор ямар нэг болзол заагаагүй. Үндэсний засгийн газар нь орон нутгийн засаг захиргаанд албан бичиг илгээж, өөрийн шийдвэрийг мэдэгдсэн; үүнд зээлийг хүчингүй болгосон талаар дурдсан зээлийн баримт бичгийг бас хавсаргадаг.

ХЗУ29. Ийм шийдвэрийг хүргэн танилцуулсан албан бичиг болон зээлийн баримт бичгийг үндэсний засгийн газраас хүлээн авсан үедээ орон нутгийн засаг захиргаа нь зээлийн өглөгийг үл хүлээн зөвшөөрөх ба уг өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрсөн тайлант үеийн санхүүгийн үр дүнгийн тайланд орлогыг хүлээн зөвшөөрдөг.

*Арилжааны болон арилжааны бус бүрэлдэхүүн хэсгүүд бүхий үл хөдлөх хөрөнгийн худалдан авалт (8-11 ба 39-41-р параграф)*

ХЗУ30. Улсын сургууль (тайлагнагч байгууллага) нь 100,000ТН-ийн бодит үнэ цэнэтэй газрыг орон нутгийн засаг захиргаанаас 50,000ТН-ээр худалдан авсан. Тухайн арилжааны бус ажил гүйлгээ нь арилжааны бүрэлдэхүүн хэсэг ба арилжааны бус бүрэлдэхүүн хэсэг гэсэн хоёр хэсгээс бүрдэж байна гэж уг тайлагнагч байгууллага дүгнэсэн. Нэг бүрэлдэхүүн хэсэг нь газрын тэн хагасыг 50,000ТН-ээр худалдан авахтай холбоотой, харин нөгөө бүрэлдэхүүн хэсэг нь газрын үлдсэн тэн хагасыг тус сургуульд шилжүүлэх арилжааны бус ажил гүйлгээ юм.

ХЗУ31. Уг ажил гүйлгээ хийгдсэн тайлант үеийн нийтлэг зорилготой санхүүгийн тайланд улсын тус сургууль нь газрыг 100,000ТН-ээр (50,000ТН-ийн өртөг

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

ба 50,000ТН-ийн шилжүүлэг) хүлээн зөвшөөрнө. Энэ нь түүний мөнгөн хөрөнгийн 50,000ТН-ийн бууралт ба арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн 50,000ТН-ийн орлого (хүлээн зөвшөөрсөн цэвэр хөрөнгийн өсөлтийн бодит үнэ цэнэ) байна.

*Санал болгосон, өвлүүлсэн хөрөнгө (90-92-р параграф)*

ХЗУ32. Улсын их сургуулийг саяхан төгсөгч 25-н настай хүн (шилжүүлэгч) нь өөрийн гэрээслэлдээ үндсэн өв залгамжлагчаар тус их сургуулийг (тайлагнагч байгууллагыг) нэрлэн заасан. Үүнийг тухайн их сургуульд хүргэн танилцуулсан. Тэрхүү төгсөгч нь гэрлээгүй, хүүхэдгүй бөгөөд одоогоор 500,000ТН-ийн үнэ цэнэ бүхий өв хөрөнгөтэй байна.

ХЗУ33. Тус гэрээслэл үйлдсэн тайлант үеийн нийтлэг зорилготой санхүүгийн тайландаа улсын их сургууль нь ямар нэг хөрөнгө буюу орлогыг хүлээн зөвшөөрөхгүй. Өвлүүлсэн хөрөнгөнд хамаарах өнгөрсөн үйл явдал нь тухайн гэрээслэгч (шилжүүлэгч)-ийн нас баралт бөгөөд ийм үйл явдал гарч тохиолдоогүй байна.

*Амлалт - Улсын эмнэлэгт зориулан телевизээр явуулсан уриалга (104-р параграф)*

ХЗУ34. 20Х5 оны 6 дугаар 30-ны орой, орон нутгийн телевиз нь улсын эмнэлэгт (тайлагнагч байгууллага)-д зориулан хандив цуглуулах уриалга явуулсан. Тус улсын эмнэлгийн тайлант жилийн эцэс нь 6 дугаар 30 байдаг. Телевиз үзэгчид нь тодорхой хэмжээний мөнгийг хандив болгож илгээхээ утас буюу цахим шуудангаар амласан. Уриалгын үр дүнд 2 сая ТН-ийг өгөхөөр амласан байв. Тухайн амласан хандив нь амлалт өгсөн хүмүүсийн хувьд заавал биелүүлэх үүрэг биш юм. Амласан хандивын ойролцоогоор 75 хувийг цуглуулдаг гэдгийг өмнөх уриалгуудын туршлага харуулж байна.

ХЗУ35. Улсын эмнэлэг нь уг амлалттай холбоотойгоор өөрийн нийтлэг зорилготой санхүүгийн тайланд ямар нэг дүнг хүлээн зөвшөөрөхгүй. Амласан нөөцийн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхид тэдгээр хэтийн шилжүүлэгч нар хандан нэвтэрч, ашиглахыг тус байгууллага нь хязгаарлаж эсвэл зохицуулж чадахгүй учраас тэрхүү амлалттай холбоотой нөөцийн хувьд уг байгууллага нь хяналт тогтоогоогүй байна. Иймээс хандив нь тухайн хандивлагчийн заавал биелүүлэх үүрэг болох хүртэл тус байгууллага нь хөрөнгө болон холбогдох орлогыг хүлээн зөвшөөрөхгүй.

*Торгууль (88-89-р параграф)*

ХЗУ36. Нэгэн томоохон корпорацийг голын ус бохирдуулсан гэм буруутай гэж тогтоосон. Бохирдлыг цэвэрлэх ба 50 сая ТН-ийн торгууль төлөх хариуцлагыг тус корпорацид хүлээлгэсэн. Уг компани нь санхүүгийн боломж сайтай бөгөөд торгуулийг төлөх чадвартай. Тус компани нь энэ хэргийн талаар давж заалдахгүй гэдгээ мэдэгдсэн.

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

ХЗУ37. Засгийн газар (тайлагнагч байгууллага) нь уг торгуулийг ногдуулсан тухайн тайлант үеийн нийтлэг зорилготой санхүүгийн тайландаа 50 сая ТН-ээр авлага ба орлогыг хүлээн зөвшөөрнө.

*Хүлээн зөвшөөрсөн гадаадын тусламж (76-82-р параграф)*

ХЗУ38. “А” үндэсний засгийн газар (тайлагнагч байгууллага) нь “Б” үндэсний засгийн газартай гадаадын тусламжийн гэрээ байгуулсан. Гэрээний дагуу, “А” үндэсний засгийн газрын эрүүл мэндийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд хоёр жилийн хугацаанд дэмжлэг үзүүлэхийн тулд “А” үндэсний засгийн газарт хөгжлийн буцалтгүй тусламж олгох юм. Уг гадаадын тусламжийн гэрээ нь хоёр талын аль алины хувьд заавал биелүүлэх гэрээ байдаг. “А” үндэсний засгийн газрын авах хөгжлийн буцалтгүй тусламжийн дэлгэрэнгүй задаргааг тус гэрээнд тусгайлан заасан. “А” засгийн газар нь хөгжлийн буцалтгүй тусламжийн бодит үнэ цэнийг 5 сая ТН гэж хэмжсэн.

ХЗУ39. Тус гадаадын тусламжийн гэрээ нь заавал биелүүлэх гэрээ болох үед “А” үндэсний засгийн газар нь 5 сая ТН-ээр хөрөнгө (авлага), мөн түүнчлэн уг дүнгээр орлогыг хүлээн зөвшөөрнө. Гэрээ нь заавал биелүүлэх гэрээ болох үед эдгээр нөөц нь хөрөнгийн тодорхойлолтыг хангах ба хүлээн зөвшөөрөх шалгуурыг биелүүлэх юм. Өр төлбөр хүлээн зөвшөөрөхийг тухайн байгууллагаас шаардах тийм нөхцөл энэхүү гэрээнд тусгагдаагүй.

*Тусламжийн агентлагийн орлого (76 ба 93-97-р параграф)*

ХЗУ40. Ногоон-Тусламж агентлаг нь засгийн газруудын бүлгээс авах санхүүжилтэнд түшиглэн үйл ажиллагаагаа явуулдаг. Засгийн газрууд нь албан ёсны гэрээнд гарын үсэг зурсан бөгөөд тус Ногоон-Тусламж агентлагийн батлагдсан төсөвт засгийн газар тус бүрийн оруулах санхүүжилтийн хувь хэмжээг уг гэрээгээр тодорхойлдог. Ногоон-Тусламж агентлаг нь санг бүрдүүлсэн төсвийн жилийн зардалд зөвхөн зориулан уг мөнгө санг ашиглаж болно. Ногоон-Тусламж агентлагийн санхүүгийн жил нь 01 дүгээр сарын 01-нд эхэлдэг. Ногоон-Тусламж агентлагийн төсвийг өмнөх жилийн 10 дугаар сард баталдаг бөгөөд төсөв батлагдсанаас хойш 10 хоногийн дараа нэхэмжлэлийг тэдгээр бие даасан засгийн газруудад цахим шуудангаар илгээдэг. Зарим засгийн газар нь тухайн санхүүгийн жил эхлэхээс өмнө, зарим нь санхүүгийн жилийн дундуур санхүүжилтийг төлдөг. Гэвч өнгөрсөн туршлагаас харахад зарим засгийн газар нь өөрсдийн төлөх ёстой мөнгийг тухайн санхүүгийн жилд ч, ирээдүйд ч төлөхгүй байх магадлалтай байдаг.

ХЗУ41. 20Х8 оны төсвийн жилийн хувьд төлбөрийн дүн ба төлөх хугацаа дараах байдалтай байна:

	(Сая ТН)
20Х7 оны 10 дугаар сарын 24-нд батлагдсан төсөв	55
20Х7 оны 11 дүгээр сарын 04-д нэхэмжилсэн дүн	55
20Х7 оны 12 дугаар сарын 31-нээр хүлээн авсан шилжүүлэг	15
20Х8 онд хүлээн авсан шилжүүлэг	38
20Х8 оны 12 дугаар сарын 31-нээр хүлээн аваагүй бөгөөд хүлээн авах магадлал багатай дүн	2



АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

ХЗУ42. Ногоон-Тусламж агентлаг нь шилжүүлгийг хүлээн авч, өөрийн банкны дансанд байршуулсан үед тухайн хөрөнгөнд хяналт тогтоох учраас 20Х8 он эхлэхээс өмнө хүлээн авсан шилжүүлгийн дүнгээр 15 сая ТН-ийн хөрөнгийг 20Х7 онд хүлээн зөвшөөрнө. Урьдчилж хүлээн авсан орлого болох 15 сая ТН-тэй тэнцүү дүнгээр өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

ХЗУ43. 20Х8 онд Ногоон-Тусламж агентлаг нь шилжүүлгээс 53 сая ТН-ийн орлогыг хүлээн зөвшөөрнө. Нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн тодруулгадаа тус агентлаг нь 55 сая ТН-ийг нэхэмжилсэн ба 2 сая ТН-ийн найдваргүй авлагын нөөц байгуулсан гэсэн тайлбар тэмдэглэл хийнэ.

*Орлого гэж хүлээн зөвшөөрсөн, хариу төлбөргүй бараа (42 ба 93-97-р параграф)*

ХЗУ44. Шилжүүлэгч “А” засгийн газар нь улсын секторын тайлагнагч байгууллага болох Тусламжийн агентлагтай гэрээ байгуулсан. Уг гэрээнд зааснаар, “А” засгийн газар нь Тусламжийн агентлагт амласан санхүүгийн үүргээ биелүүлэхийн тулд цагаан будаа нийлүүлнэ. Өөрийн үүргийг биелүүлэх “А” засгийн газрын өмнөх гүйцэтгэлийн хувьсан өөрчлөлтөнд үндэслэн тус Тусламжийн агентлаг нь уг амласан цагаан будааг хүлээн авах хүртэл хөрөнгө ба орлого хүлээн зөвшөөрөхгүй байх нягтлан бодох бүртгэлийн бодлого баримталдаг. “А” засгийн газар нь 20Х5 онд уг Тусламжийн агентлагт 300,000 ТН-ийн тусламж үзүүлэхээр амласан. Үүний дараа 20Х5 оны 01 дүгээр сарын 12-нд “А” засгийн газар нь 1,000 тонн цагаан будааг Тусламжийн агентлагт шилжүүлэн өгсөн. Будааны шилжүүлэлт нь тухайн шилжүүлэгч улсын нэгэн боомт дээр хийгдсэн. Тусламжийн агентлаг ба “А” засгийн газар хоорондох санхүүжилтийн гэрээнд дэлгэрэнгүй заасанчлан, цагаан будааны тонн тутмыг өмнө тохиролцсон 300ТН-ээр үнэлсэн бөгөөд 1,000 тонн цагаан будааг шилжүүлсэний үр дүнд “А” засгийн газар нь 300,000 ТН-ийн санхүүгийн үүргээ бүрэн биелүүлсэн. 20Х5 оны 2 ба 3 дугаар сард Тусламжийн агентлаг нь өлсгөлөнд нэрвэгдсэн хүмүүст зориулан Б болон В улсын орон нутгийн дистрибьютор агентлагуудын сүлжээгээр дамжуулан будааг тараан хуваарилсан.

ХЗУ45. 20Х5 оны 01 дүгээр сарын 12-нд 1,000 тонн цагаан будааны зах зээлийн үнэ нь “А” засгийн газрын улсын хувьд 280,000ТН, хэрэглээний барааны олон улсын зах зээлд 250,000ТН, хүлээн авагч “Б” улсад 340,000ТН, В улсад 400,000ТН тус тус байсан.

ХЗУ46. Тусламжийн агентлагийн хүлээн зөвшөөрөх орлогыг хэмжихийн тулд уг хандивыг хүлээн авсан өдрөөр цагаан будааны бодит үнэ цэнийг тодорхойлох ёстой. Цагаан будааны тонн тутмыг 300ТН-ээр үнэлэхийг зөвшөөрсөн, хандивлагч ба тусламжийн агентлагийн хоорондох санхүүгийн хэлцэл нь хоёр талын хоорондох хувийн тохиролцооноос хамаарах бөгөөд цагаан будааны бодит үнэ цэнийг заавал тусгасан байх албагүй юм. Тусламжийн агентлаг болон хандивлагч “А” засгийн газрын аль аль нь цагаан будааг дэлхийн зах зээл дээрээс арай бага үнэ болох 250,000ТН-ээр худалдан авах сонголттой байна. Бие даасан улс

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

орнуудын хувьд зах зээлийн үнэ нь худалдааны хориг саад эсвэл хүлээн авагч улс дахь хүнсний ноцтой хомсдлоос үүссэн түр зуурын тэнцвэргүй байдлын улмаас ихээхэн хэлбэлзэлтэй байх бөгөөд зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа худалдан авагч ба борлуулагчдын хоорондох хэвийн ажил гүйлгээгээр хийгдэх шилжүүлгийн үнийг тусгаагүй байж болох юм. Иймээс дэлхийн зах зээлийн үнэ болох 250,000ТН нь уг хандивласан цагаан будааны бодит үнэ цэнийн хамгийн найдвартай ба хамгийн зохистой илэрхийлэл болно. Тусламжийн агентлаг нь уг шилжүүлгийг хүлээн авсан тайлант жилийн нийтлэг зорилготой санхүүгийн тайландаа 250,000ТН-ээр хөрөнгө (будаа) ба орлогын өсөлтийг хүлээн зөвшөөрнө.

*Хүлээн зөвшөөрөөгүй, хариу төлбөргүй үйлчилгээний тодруулга (98-102 ба 108-р параграф)*

ХЗУ47. Тухайн хүлээн авсан сайн дурын үйлчилгээ нь хөрөнгийн тодорхойлолтыг хангах ба хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг биелүүлэх тохиолдолд улсын эмнэлэг (тайлагнагч байгууллага) нь тэрхүү үйлчилгээг хөрөнгө ба орлого гэж хүлээн зөвшөөрөх нягтлан бодох бүртгэлийн бодлого баримталдаг. Тус эмнэлэг нь зохион байгуулалттай хөтөлбөрийн нэг хэсэг байдлаар сайн дурын үйлчилгээг хүлээн авдаг. Хөтөлбөрийн үндсэн зорилго нь сайн дурын ажилтныг эмнэлгийн орчинтой танилцуулах ба ажил мэргэжлийн туршлага болгон сувилгаа асаргаа хийхэд дэмжлэг үзүүлэх явдал юм. Сайн дурын ажилтан наад зах нь 16-н настай байх ёстой бөгөөд эхлээд 6-н сарын хугацаанд долоо хоногт нэг удаа өглөө буюу оройн ээлжинд 4 цаг ажиллах шаардлагатай. Сайн дурын ажилтан бүрийн хувьд эхний ээлж нь эмнэлэгтэй танилцах сургалтын хэсгээс бүрддэг. Орон нутгийн олон ахлах сургууль нь өөрийн боловсролын хөтөлбөрийн нэг хэсэг болгон ийм ажил эрхлэхийг өөрийн сурагчдад зөвшөөрдөг. Сайн дурын ажилтнууд нь зохих эрх бүхий сувилагчийн удирдлаган дор ажиллах ба өвчтөнүүдийг эргэж очих, тэдэнд ном, сэтгүүл уншиж өгөх гэх мэт сувилгааны бус үүргийг гүйцэтгэдэг. Тус улсын эмнэлэг нь сайн дурын ажилтнуудад мөнгө төлдөггүй, мөн ийм сайн дурын ажилтнууд байгаагүй бол тэдний ажлыг гүйцэтгүүлэхийн тулд хүмүүсийг хөлслөн ажиллуулахгүй байсан.

ХЗУ48. Эмнэлэг нь сайн дурын ажилтнуудтай байгуулсан гэрээнд дүн шинжилгээ хийсэн бөгөөд шинэ сайн дурын ажилтны хамгийн наад зах нь эхний 6 сарын хугацаанд үзүүлсэн үйлчилгээний хувьд хөрөнгийн хяналтын тодорхойлолтыг хангахуйцаар хангалттай хяналт тавьдаг гэж дүгнэсэн. Сайн дурын ажилтны үйлчилгээг хүлээн авч байгаа нь хөрөнгийн тодорхойлолтыг хангана гэж тус эмнэлэг бас дүгнэсэн. Гэвч тус эмнэлэгт эсвэл тухайн бүс нутгийн бусад эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн байгууллагуудад үүнтэй адилтгах цалин хөлс төлдөг ажлын байр байхгүй учраас сайн дурын ажилтны үзүүлсэн үйлчилгээний бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадахгүй гэж дүгнэсэн. Иймээс тус эмнэлэг нь сайн дурын ажилтнуудын үзүүлсэн, хариу төлбөргүй үйлчилгээг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрдөггүй. Эмнэлэг нь тухайн тайлант үеийн туршид сайн дурын ажилтнуудын үзүүлсэн үйлчилгээний цагийн тоо

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

болон үзүүлсэн үйлчилгээний тайлбар тодорхойлолтын хувьд тодруулга хийдэг.

*Эздийн хувь оролцоо (37-38-р параграф)*

ХЗУ49. 20Х0 онд Алтонае, Беролини, Кадоми гэдэг хөрш зэргэлдээ хотууд нь Гурван Хотын Цахилгаан Түгээх Үйлчилгээ (ГХЦТҮ) (тайлагнагч байгууллага)-г үүсгэн байгуулсан. ГХЦТҮ-г үүсгэн байгуулах дүрэм нь хотын захиргаадын заавал биелүүлэх баримт бичиг бөгөөд дүрэмд зааснаар, тэдгээр нь тэнцүү өмчлөлийн хувь оролцоотой байна. Үүнийг зөвхөн харилцан тохиролцон өөрчилж болох юм. ГХЦТҮ-г байгуулахын тулд хот бүр нь 25 сая ТН-ийн хувь оруулсан. Эдгээр хувь оролцоо нь эздийн хувь оролцооны тодорхойлолтыг хангах ба тухайн байгууллага нь эздийн хувь оролцоо гэж хүлээн зөвшөөрсөн. Түүнчлэн дүрэмд зааснаар, хотууд нь ГХЦТҮ-ний гарц бүтээгдэхүүнийг өөрсдийн өмчлөлтэй хувь тэнцүү байдлаар худалдан авах ёстой. Худалдан авах үнэ нь үйлдвэрлэлийн бүрэн өртөгтэй тэнцүү байна. 20Х9 онд Беролини хот нь өөрийн нутаг дэвсгэрт хөнгөн цагаан хайлуулах үйлдвэр барих зөвшөөрөл олгосон бөгөөд энэ нь тус хотын цахилгааны хэрэглээг хоёр дахин нэмэгдүүлэх юм. Нэмэлт цахилгаан үйлдвэрлэх хүчин чадал бүхий байгууламж барихын тулд Беролини хот өөрийн хувь оролцоогоо нэмэгдүүлэх боломж олгохын тулд тус гурван хот нь ГХЦТҮ-ний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн. ГХЦТҮ-ний хараат бус үнэлгээний эцэст Беролини хот нь эздийн хувь оролцоо болгон 50 сая ТН-ийг оруулах ба өөрийн өмчлөлийн хувь оролцоог 49.9% болгож өсгөх, Алтонае ба Кадоми хотууд тус бүр 25.05% өмчлөлтэй байхыг тэдгээр хотууд зөвшөөрсөн.

ХЗУ50. Дүрмийн өөрчлөлт нь заавал биелүүлэх баримт бичиг болсон тохиолдолд ГХЦТҮ нь 50 сая ТН-ийн хөрөнгийн өсөлт (мөнгө эсвэл эздээс авах хувь оролцооны авлага) болон 50ТН-ийн эздийн хувь оролцооны өсөлтийг хүлээн зөвшөөрнө.

*Өр төлбөр хүлээн зөвшөөрөхийг шаардахгүй, буцалтгүй тусламжийн гэрээний нөхцөл (20-25-р параграф)*

ХЗУ51. “А” улсын Үндэсний Цэцэрлэгт Хүрээлэн нь “Б” улсын хоёр талын хамтын тусламжийн агентлагаас 500,000 ТН-ийн буцалтгүй тусламж хүлээн авсан. “А” улсын одоогийн онгон байгалийн ойн устсан хэсгийг нөхөн сэргээхэд уг буцалтгүй тусламжийг ашиглан зарцуулах шаардлагатай бөгөөд хэрэв мөнгийг зориулалтын дагуу зарцуулахгүй бол “Б” улсад буцаан өгөх ёстой гэсэн болзлыг энэхүү тусламжийн гэрээнд заасан. Буцалтгүй тусламжийн гэрээний нөхцөл нь “А” улсын болон олон улсын шүүхээр хууль ёсны хүчин төгөлдөр хэрэгжих боломжтой юм. Тус Үндэсний Цэцэрлэгт Хүрээлэн нь уг шилжүүлэгчээс энэ төрлийн буцалтгүй тусламжийг 13 дахь жилдээ хүлээн авч байна. Өмнөх жилүүдэд буцалтгүй тусламжийг болзолд заасны дагуу ашиглаагүй боловч уг цэцэрлэгт хүрээлэнг өргөжүүлэхэд зориулан түүний зэргэлдээх нэмэлт газрыг худалдан авахад тухайн тусламжийг ашиглан зарцуулсан. Үндэсний Цэцэрлэгт Хүрээлэн нь

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

ойн устсан хэсэгт өнгөрсөн 13-н жилийн хугацаанд ямар нэг нөхөн сэргээлт хийгээгүй. “Б” улсын хоёр талын хамтын тусламжийн агентлаг нь уг гэрээний нөхцөл зөрчигдөж байгааг мэдэж байсан.

ХЗУ52. Үндэсний Цэцэрлэгт Хүрээлэн нь уг ажил гүйлгээнд дүн шинжилгээ хийж, хэдийгээр буцалтгүй тусламжийн гэрээний нөхцлийг хууль ёсоор хүчин төгөлдөр хэрэгжүүлэх боломжтой боловч тус хоёр талын хамтын тусламжийн агентлаг нь өнгөрсөн хугацаанд тэрхүү нөхцлийг хууль ёсоор албадан хэрэгжүүлээгүй бөгөөд цаашид ч ингэж хэрэгжүүлэх шинж тэмдэг байхгүй учраас гэрээний заалт нь хэлбэрийн хувьд болзол ба нөхцөл боловч мөн чанарын хувьд тийм биш гэж дүгнэсэн. Үндэсний Цэцэрлэгт Хүрээлэн нь хөрөнгө (банкин дахь мөнгө) ба буцалтгүй тусламжийн орлогын өсөлтийг хүлээн зөвшөөрнө; ямар нэг өр төлбөр хүлээн зөвшөөрөхгүй.

*“А” засгийн газрын санхүүгийн тайланд хийсэн тодруулга (106-108-р параграф)*

ХЗУ53. 20Х2 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жилд “А” засгийн газар нь анх удаагаа УСНББОУС-ын дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэн толилуулж байна. Тус засгийн газар нь өөрийн санхүүгийн тайланд дараах тодруулгыг хийсэн:

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

**Санхүүгийн үр дүнгийн тайлан**

	<b>20X2</b> <b>(Мянган ТН)</b>	<b>20X1</b> <b>(Мянган ТН)</b>
<b>Арилжааны бус ажил гүйлгээний орлого</b>		
<b>Татварын орлого</b>		
Орлогын татварын орлого (Тодруулга 4 ба 8)	XXX	XXX
Бараа, үйлчилгээний татвар (Тодруулга 5)	XXX	XXX
Өв хөрөнгийн татвар (Тодруулга 6 ба 9)	XX	XX
<b>Шилжүүлгийн орлого</b>		
Бусад Засгийн газраас авсан шилжүүлэг (Тодруулга 7)	XXX	XXX
Бэлэг, хандив, хариу төлбөргүй бараа (Тодруулга 13)	X	X
Хариу төлбөргүй үйлчилгээ (Тодруулга 15 ба 16)	X	X

**Санхүүгийн байдлын тайлан**

<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
Банкны харилцах данс	XX	XX
<b>Татварын авлага</b>		
Бараа, үйлчилгээний татварын авлага (Тодруулга 5)	XX	XX
<b>Шилжүүлгийн авлага</b>		
Бусад засгийн газраас авах шилжүүлгийн авлага (Тодруулга 7)	X	X
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Газар (Тодруулга 11)	XXX	XXX
Үндсэн хөрөнгө (Тодруулга 12 ба 14)	XX	XX
<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
Шилжүүлгийн гэрээний дагуу хүлээн зөвшөөрсөн өр төлбөр (Тодруулга 10)	XX	XX
Урьдчилж орсон орлого		
Татвар		
Шилжүүлэг		

## Санхүүгийн тайлангийн тодруулга

### Нягтлан бодох бүртгэлийн бодлого

#### **Арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн орлогын хүлээн зөвшөөрөлт**

1. Татвар ногдуулах ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгө ба орлогыг УСНББОУС 23, *Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Татвар ба Шилжүүлэг)*-ын шаардлагуудын дагуу хүлээн зөвшөөрдөг. Гэвч засгийн газар нь орлогын татвар болон өв хөрөнгийн татварт хамаарах шилжилтийн нөхцлийн давуу талуудыг ашигладаг.

Орлогын татвар ба өв хөрөнгийн татвараас бусад, татвар ногдуулах ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгө ба орлогыг хэрэв тухайн хөрөнгө нь хөрөнгийн тодорхойлолтыг хангах бөгөөд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг биелүүлж байвал тэрхүү татвар ногдох ажил гүйлгээ гарч тохиолдсон тайлант үед хүлээн зөвшөөрдөг. Орлогын татвар ба өв хөрөнгийн татварыг тэрхүү татварын төлбөрийг хүлээн авсан тайлант үед хүлээн зөвшөөрдөг (Тодруулга 4 ба 6-г үзнэ үү).

2. Зарим хариу төлбөргүй үйлчилгээнээс бусад, шилжүүлгийн ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгө ба орлогыг тухайн шилжүүлгийн гэрээ нь заавал биелүүлэх гэрээ болсон тайлант үед хүлээн зөвшөөрдөг. Засгийн газар нь зөвхөн зохион байгуулалттай хөтөлбөрийн нэг хэсэг байдлаар хүлээн авсан бөгөөд зах зээлийн үнийг лавлагаа болгосноор бодит үнэ цэнийг нь тодорхойлж чадах хариу төлбөргүй үйлчилгээг хүлээн зөвшөөрдөг. Үүнээс бусад, хариу төлбөргүй үйлчилгээг хүлээн зөвшөөрдөггүй.
3. Хэрэв нөхцлийг биелүүлэхгүй бол тухайн шилжүүлсэн нөөцийг буцаахыг шаарддаг нөхцөл бүхий шилжүүлгийн хувьд засгийн газар нь уг нөхцөл биелэгдэх хүртэл өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг.

*Арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн орлогын гол ангиудын хэмжилтийн суурь*

#### **Татвар**

4. Орлогын татварын орлогыг тухайн тайлант үеийн туршид хүлээн авсан мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийн нэрлэсэн үнэ цэнээр хэмждэг. Засгийн газар нь орлогын татварын орлогыг аккруэл сууриар хэмжих статистик загварыг одоо боловсруулж байна. Уг загвар нь 19Х2 оноос хойш гаргасан татварын статистик мэдээ, түүнчлэн долоо хоног тутмын дундаж орлого, дотоодын нийт бүтээгдэхүүн, хэрэглэгчийн болон үйлдвэрлэгчийн үнийн индекс зэрэг бусад статистик мэдээллийг ашигладаг. Энэхүү загвар нь 20Х4 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жилийн хувьд орлогын татварын орлогыг аккруэл сууриар найдвартай хэмжих боломжийг түүнд олгоно гэж засгийн газар нь төсөөлж байна. Засгийн газар нь орлогын татварын авлагын хувьд ямар нэг дүнг хүлээн зөвшөөрдөггүй.

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

5. Бараа, үйлчилгээний татвараас үүсэх хөрөнгө болон орлогыг тухайн тайлант үеийн туршид засгийн газарт орох хөрөнгийн, үндсэндээ мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө, бараа ба үйлчилгээний татварын авлагын бодит үнэ цэнээр эхлээд хэмждэг. Тухайн тайлант жилийн туршид татвар төлөгчдийн гарган танилцуулсан бараа, үйлчилгээний татварын тайлан болон засгийн газарт төлөхөөр тооцоолсон бусад дүнгүүдээс уг мэдээллийг эмхэтгэн бүрдүүлдэг. Татвар төлөгчид нь 20X0 онд суурилуулсан цахим тайлангийн системийг ашиглан татварын хууль тогтоомжийг чанд даган мөрддөг бөгөөд алдааны түвшин бага байдаг. Татварын хууль тогтоомжийн чанд даган мөрдөлт ба алдаа бага гаргалт нь тухайн татвараас үүсэх орлогыг хэмжих найдвартай статистик загвар боловсруулах боломжийг засгийн газарт олгодог.

Бараа, үйлчилгээний татварын авлага нь тухайн тайлант үед хамаарах татвараас төлөгдөх бөгөөд 20X2 оны 12 дугаар сарын 31-нээр төлөгдөөгүй үлдсэн үлдэгдлээс найдваргүй авлагын нөөцийг хассан дүнгийн тооцоолол юм.

6. Нас барагсдын бүх өв хөрөнгөнд 40 хувиар өв хөрөнгийн татвар ногдуулдаг боловч өв хөрөнгө бүрийн эхний 400,000ТН-ийг татвараас чөлөөлдөг. Өв хөрөнгийн татвараас үүсэх хөрөнгө ба орлогыг тухайн тайлант үед хүлээн авсан мөнгөний нэрлэсэн үнээр эсвэл тэрхүү тайлант үеийн туршид хүлээн авсан бусад хөрөнгийн уг олж эзэмшсэн өдрийн бодит үнэ цэнээр хэмждэг. Бодит үнэ цэнийг зах зээлийн үнэлгээг лавлагаа болгосноор эсвэл үнэлгээний мэргэжлийн гишүүний хараат бус үнэлгээгээр тодорхойлдог.

*Шилжүүлгийн орлого*

7. Шилжүүлгийн үр дүнд хүлээн зөвшөөрөх хөрөнгө ба орлогыг уг хүлээн зөвшөөрөлтийн өдрөөр хүлээн зөвшөөрсөн тухайн хөрөнгийн бодит үнэ цэнээр хэмждэг. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ нь материаллаг байх, ингэснээр тухайн хөрөнгийг эзэмшихтэй холбоотой угийн эрсдлийг тусгах дискаунтын хувийг ашигласнаар тооцоолсон мөнгөний өнөөгийн үнэ цэнийг ашиглахаас бусад тохиолдолд мөнгөн зүйлсийн хөрөнгийг тэдгээрийн нэрлэсэн үнэ цэнээр хэмждэг. Мөнгөн зүйлсийн бус хөрөнгийг тэдгээрийн бодит үнэ цэнээр хэмждэг. Бодит үнэ цэнийг ажиглаж болох зах зээлийн үнэ цэнийг лавлагаа болгосноор эсвэл үнэлгээний мэргэжлийн байгууллагын гишүүний хараат бус үнэлгээгээр тодорхойлдог. Шилжүүлгийн заавал биелүүлэх гэрээтэй боловч мөнгө буюу бусад хөрөнгийг хүлээн аваагүй тохиолдолд авлагыг хүлээн зөвшөөрдөг.

*Татвар ногдох үйл явдал гарч тохиолдсон тайлант үед найдвартай хэмжих боломжгүй татвар*

8. Засгийн газар нь бүх татвар төлөгчдийн орлогоо олсон тухайн тайлант үеийн туршид орлогын татвараас үүсэх хөрөнгүүдийг шууд хэмжих боломжгүй байдаг. Иймээс татвар төлөгчдийн орлого олсон тухайн тайлант үед татварын орлогыг шууд бусаар хэмжих загвар боловсруулахын тулд УСНББОУС 23, *Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Татвар ба Шилжүүлэг)*-ын шилжилтийн нөхцлийн давуу талыг

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

ашигладаг. Засгийн газар нь 20X4 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант үеийн хувьд уг загварыг ашигласнаар орлогын татварыг аккруэл сууриар найдвартай хэмжих боломжтой болно гэж үзэж байна.

9. Татварын хуулийн одоогийн үл даган мөрдөлтийн өндөр түвшний улмаас өв хөрөнгийн татварын хувьд засгийн газар нь тухайн татвар ногдох үл хөдлөх хөрөнгийг өмчлөгч хүн нас барсан тайлант үед үүсэх хөрөнгө ба орлогын дүнг хэмжих боломжгүй байна. Иймээс засгийн газар нь татварын төлбөрийг хүлээн авсан үед өв хөрөнгийн татварыг хүлээн зөвшөөрдөг. Татварын алба нь татвар ногдох үйл явдал гарч тохиолдсон тухайн жилд уг хөрөнгийн авлага ба орлогыг хэмжих найдвартай аргыг боловсруулахын тулд ажилласаар байна.

*Шилжүүлгийн хувьд хүлээн зөвшөөрсөн өр төлбөр*

10. 20X2 оны 12 дугаар сарын 31-нд засгийн газар нь улсын эмнэлэг барих нөхцөлтэйгээр түүнд өгсөн шилжүүлгийн хувьд ХХ,000 ТН-ийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн. Хэдийгээр барилгын ажлын тендерийг 20X2 оны 11 дүгээр сарын 30-нд зарласан боловч эмнэлгийн барилгын ажлыг эхлээгүй байхад засгийн газар нь 12 дугаар сарын 31-нд мөнгийг хүлээн авсан.

*Хязгаарлалт бүхий хөрөнгө*

11. 20X2 онд ХХ,000 ТН-ийн бодит үнэ цэнэ бүхий газрыг олон нийтийн эрүүл мэндийн зорилгоор ашиглах ба 50 жилийн хугацаанд худалдан борлуулахгүй байх хязгаарлалттай бүхий хандив байдлаар хүлээн авсан. Шилжүүлэгч нь тухайн газрыг ингэж шилжүүлэхийн яг өмнөхөн нийтийн дуудлага худалдаагаар олж эзэмшсэн бөгөөд дуудлага худалдааны үнэ нь түүний бодит үнэ цэнэ юм.
12. Үндсэн хөрөнгөнд ХХ,000 ТН-ийн дансны үнэтэй уран зураг байдаг. Тус зургийг засгийн газрын хяналтанд байдаг уран зургийн галерей нь 19X2 онд хандив байдлаар хүлээн авсан бөгөөд түүнийг 40 жилийн хугацаанд худалдан борлуулахгүй гэсэн хязгаарлалттай. Уг зургийг хараат бус үнэлгээгээр тогтоосон түүний бодит үнэ цэнээр хэмжсэн.

*Өвлүүлсэн хөрөнгө, бэлэг, хандив болон хүлээн авсан, хариу төлбөргүй барааны гол ангиуд*

13. Бэлэг, хандив, хариу төлбөргүй бараа хэлбэрээр хүлээн авдаг шилжүүлэг нь ихэвчлэн эмнэлгийн болон сургуулийн хангамжийн зүйлс (бараа материал), эмнэлгийн ба сургуулийн тоног төхөөрөмж, урлагийн бүтээл (үндсэн хөрөнгө гэж ангилсан) байдаг. Бэлэг ба хандивыг үндсэндээ хувь хүн сайн үйлс бүтээгчдээс хүлээн авдаг. Засгийн газрын хяналтанд байдаг эмнэлэг, сургааль, урлагийн галерей нь мөнгө буюу үндсэн хөрөнгө хэлбэрээр нөөцийг ихэвчлэн хүлээн авч, хяналт түүнд шилжсэн үед эдгээр хөрөнгийг хүлээн зөвшөөрдөг. Тухайн шилжүүлгийн бодит үнэ цэнэ нь ХХ,000 ТН-ээс хэтрэхгүй байх тохиолдолд засгийн газар нь нөхцөл буюу хязгаарлалт бүхий ийм шилжүүлгийг хүлээн зөвшөөрдөггүй.
14. “С” засгийн газартай байгуулсан гадаадын тусламжийн гэрээний нэг хэсэг болгон 20X2 онд ХХ,000 ТН-ийн бодит үнэ цэнэ бүхий компьютерыг



АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

боловсролын байгууллагад ашиглуулах эсвэл “С” засгийн газарт буцаан өгөх гэсэн нөхцөлтэйгээр тухайн засгийн газарт олгосон.

*Хариу төлбөргүй үйлчилгээ*

15. Засгийн газрын хяналтанд байдаг эмнэлэг нь эмнэлгийн мэргэжилтнүүдийн зохион байгуулалттай сайн дурын хөтөлбөрийн хүрээнд эмнэлгийн практик ажилтнуудаас хариу төлбөргүй эмнэлгийн үйлчилгээг авсан. Эмнэлгийн мэргэжилтнүүдийн цалин хөлсний хэвлэн нийтэлсэн схемийг лавлагаа болгосноор уг хариу төлбөргүй үйлчилгээг санхүүгийн үр дүнгийн тайландаа тэдгээрийн бодит үнэ цэнээр орлого ба зардал гэж хүлээн зөвшөөрсөн.
16. Засгийн газрын хяналтанд байдаг эмнэлэг, сургууль, урлагийн галерей нь галерейн танилцуулагч ба тайлбарлагч, багшийн туслагч, эмнэлгийн өвчтөн хүлээн авагч зэрэгт зориулсан зохион байгуулалттай хөтөлбөрийн хүрээнд сайн дурын ажилтнуудаас дэмжих үйлчилгээг мөн хүлээн авсан. Эдгээр сайн дурын ажилтнууд нь өөрсдийн зорилтуудад хүрэхэд тухайн байгууллагуудад үнэ цэнэтэй дэмжлэг үзүүлдэг. Гэвч тухайн орон нутгийн зах зээлд үүнтэй адилтгах цалин хөлс төлдөг ажлын байр байхгүй бөгөөд хэрэв сайн дурын ажилтнууд байгаагүй бол ийм үйлчилгээ үзүүлэхгүй байсан учраас тэдгээр сайн дураар үзүүлсэн үйлчилгээний бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадахгүй. Засгийн газар нь санхүүгийн байдлын болон санхүүгийн үр дүнгийн тайландаа эдгээр үйлчилгээг хүлээн зөвшөөрдөггүй.

*Хөнгөлөлттэй зээл (105А ба 105Б параграф)*

ХЗУ54. Байгууллага нь дараагийн 5 жилийн хугацаанд 10 сургууль барихын тулд олон талын хөгжлийн агентлагаас 6 сая ТН-ийн санхүүжилт хүлээн авсан. Санхүүжилтийг дараах нөхцөлтэйгээр олгосон:

- Хэрэв сургуулиудыг баривал 1 сая ТН-ийн санхүүжлтийг буцаан төлөх шаардлагагүй.
- 6 сая ТН-ийн санхүүжилтийг дараах байдлаар буцаан төлнө:  
Жил 1: Үндсэн дүнгээс буцаан төлөхгүй  
Жил 2: Үндсэн дүнгийн 10 хувийг буцаан төлнө  
Жил 3: Үндсэн дүнгийн 20 хувийг буцаан төлнө  
Жил 4: Үндсэн дүнгийн 30 хувийг буцаан төлнө  
Жил 5: Үндсэн дүнгийн 40 хувийг буцаан төлнө
- Зээлийн хугацаанд жил тутам 5 хувийн хүү тооцно (хүүний өглөгийг жил бүр төлнө гэж төсөөлөх). Адилтгах зээлийн зах зээлийн хүүний түвшин 10 хувь байсан.
- Сургуулиудыг бариагүй тохиолдолд хүлээн авсан санхүүжилтийг хандивлагчид буцааж төлнө (уг хандивлагч нь үр дүнтэй хяналт

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

үнэлгээний системтэй бөгөөд аливаа зарцуулаагүй мөнгө санг буцаахыг шаарддаг өмнөх туршлагатай гэж төсөөлөх).

- Тус байгууллага нь зээлийн хугацаанд дараах байдлаар сургуулиудыг барьсан:

Жил 1: 1 сургууль барьсан

Жил 2: 3 сургууль барьсан

Жил 3: 5 сургууль барьсан

Жил 4: 10 сургууль барьсан

### Шинжилгээ

Тус байгууллага нь 1 сая ТН-ийн буцалтгүй тусламж болон 5 сая ТН-ийн зээлийг үр дүнтэйгээр хүлээн авсан (Жич: уг 1 сая ТН-ийн хөрөнгө нь мөн чанарын хувьд эздийн хувь оролцоо эсвэл орлого эсэхийг тухайн байгууллага харгалзан үзнэ; энэ жишээний хувьд 1 сая ТН-ийн орлого гэж үзнэ). Мөн тус байгууллага нь 784,550 ТН-ийн нэмэлт буцалтгүй тусламжийг хүлээн авсан (Энэ нь 5 сая ТН-ийн зээлийн орлого ба 10 хувийн зах зээлийн холбогдох хүүний түвшинг ашиглан дискаунтчилсан уг зээлийн гэрээний мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийн хоорондох зөрүү юм).

1 сая ТН дээр 784,550ТН-ийг нэмсэн дүн болох буцалтгүй тусламжийг энэ Стандартын дагуу тайлагнах бөгөөд тухайн зээл, түүний гэрээний холбогдох хүү ба үндсэн дүнгийн төлөлтийг УСНББОУС 29-ийн дагуу тайлагнана.

1. Анх хүлээн зөвшөөрөх үед тус байгууллага нь дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

Дебит	Банкны харилцах данс	ТН 6,000,000
Кредит	Зээлийн өглөг	ТН 4,215,450
Кредит	Өр төлбөр	ТН 1,784,550

2. Жил 1: тус байгууллага нь дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

Дебит	Өр төлбөр	ТН 178,455
Кредит	Арилжааны бус орлого	ТН 178,455

(Барих сургуулийн 1/10 x ТН 1,784,550)

(Жич: энэ жишээ нь хөнгөлөлттэй зээлээс үүсэх орлогын хүлээн зөвшөөрөлтийг үлгэрчлэн харуулах зорилготой тул хүүний болон үндсэн дүнгийн буцаан төлөлт, хүүний хуримтлуулалтыг бүртгэх журналын бичилтүүдийг харуулаагүй болно. Дэлгэрэнгүй жишээг УСНББОУС 29-ийн Үлгэрчилсэн жишээнд харуулсан.)

3. Жил 2: тус байгууллага нь дараах байдлаар хүлээн зөвшөөрнө (дараагийн тайлант үед байгууллага нь уг хөнгөлөлттэй зээлийг хорогдуулсан өртгөөр хэмждэг гэж төсөөлөх):

АРИЛЖААНЫ БУС АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ОРЛОГО  
(ТАТВАР БА ШИЛЖҮҮЛЭГ)

Дебит	Өр төлбөр	ТН 356,910	
Кредит	Арилжааны бус орлого		ТН 356,910

(Барих сургуулийн 3/10 х ТН 1,784,550 – өмнө хүлээн зөвшөөрсөн дүн ТН 178,455)

4. Жил 3: тус байгууллага нь дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

Дебит	Өр төлбөр	ТН 356,910	
Кредит	Арилжааны бус орлого		ТН 356,910

(Барих сургуулийн 5/10 х ТН 1,784,550 – өмнө хүлээн зөвшөөрсөн дүн ТН 535,365)

5. Жил 4: тус байгууллага нь дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

Дебит	Өр төлбөр	ТН 892,275	
Кредит	Арилжааны бус орлого		ТН 892,275

(Бүх сургуулиуд баригдсан: ТН 1,784,550 –ТН 892,275)

Хэрэв уг хөнгөлөлттэй зээлийг ямар нэг нөхцөлгүйгээр олгосон бол анх хүлээн зөвшөөрөх үед тус байгууллага нь дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

Дебит	Банкны харилцах данс	ТН 6,000,000	
Кредит	Зээлийн өглөг		ТН 4,215,450
Кредит	Арилжааны бус орлого		ТН 1,784,550

## УСНББОУС 24–САНХҮҮГИЙН ТАЙЛАН ДАХЬ ТӨСВИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОЛИЛУУЛГА

### УСНББОУС-ЫН ТҮҮХ

Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

УСНББОУС 24, Санхүүгийн Тайлан дахь Төсвийн Мэдээллийн Толилуулга-ыг 2006 оны 12 дугаар сард гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 24-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2011-ийн Сайжруулалтууд (2011 оны 10 дугаар сард гаргасан)

### УСНББОУС 24-ийн нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт

Өөрчлөгдсөн параграф	Хэрхэн өөрчилсөн	Юугаар өөрчилсөн
Танилцуулга хэсэг	Хассан	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
3	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
4	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
26	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
46	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
54А	Шинэ	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
54Б	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
54В	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
55	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар

2006 оны 12 дугаар сар

**УСНББОУС 24–САНХҮҮГИЙН ТАЙЛАН ДАХЬ ТӨСВИЙН  
МЭДЭЭЛЛИЙН ТОЛИЛУУЛГА**

**АГУУЛГА**

---

	Параграф
Зорилго	1
Цар хүрээ	2-6
Тодорхойлолт	7-13
Батлагдсан төсөв	8-10
Анхны болон тодотгосон төсөв	11-12
Гүйцэтгэлийн дүн	13
Төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлсэн толилуулга	14-38
Толилуулга ба тодруулга	21-24
Нэгтгэлийн түвшин	25-28
Анхны төсвөөс тодотгосон төсөв болгох өөрчлөлт	29-30
Зэрэгцүүлэгдэх суурь	31-36
Олон-жилийн төсөв	37-38
Төсвийн суурь, хугацаа, цар хүрээний тэмдэглэл тодруулга	39-46
Зэрэгцүүлэгдэх сууриар тусгасан гүйцэтгэлийн дүн ба санхүүгийн тайлан дахь гүйцэтгэлийн дүнгийн хоорондох тохируулга	47-53
Хүчин төгөлдөр болох хугацаа	54-55
Дүгнэлтийн үндэслэл	
Үлгэрчилсэн жишээ	

## САНХҮҮГИЙН ТАЙЛАН ДАХЬ ТӨСВИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОЛИЛУУЛГА

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 24, *Санхүүгийн Тайлан дахь Төсвийн Мэдээллийн Толилуулга*-ыг 1-55-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 24-ийг түүний зорилгын агуулга, Дүгнэлтийн Үндэслэл, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

1. Батлагдсан төсвөө олон нийтэд нээлттэй танилцуулах шаардлагатай буюу тийм сонголт хийсэн, ингэснээр олон нийтийн өмнө төсвийн хариуцлага хүлээдэг байгууллагуудын санхүүгийн тайланд төсвийн дүн ба төсвийн хэрэгжилтийн үр дүн болох гүйцэтгэлийн дүнгийн зэрэгцүүлэлтийг тусгахыг энэхүү Стандартаар шаарддаг. Энэ Стандарт нь төсөв ба гүйцэтгэлийн дүнгийн хоорондох материаллаг зөрүүгийн учир шалтгааны тайлбарын талаархи тодруулга хийхийг шаарддаг. Энэ Стандартын шаардлагуудын мөрдөлт нь улсын секторын байгууллагууд төсвийн хариуцлагын үүргээ биелүүлсэн бөгөөд дараах зүйлсийг харуулснаар өөрсдийн санхүүгийн тайлангийн ил тод, ойлгомжтой байдлыг нэмэгдүүлсэн гэдгийг ханган магадалдаг: (а) олон нийтийн өмнө хариуцлага хүлээх уг батлагдсан төсвийн даган мөрдөлт, (б) төсөв ба санхүүгийн тайланг нэг ижил сууриар бэлтгэдэг тохиолдолд тэдгээр төсөвлөсөн үр дүнд хүрэх өөрийн санхүүгийн гүйцэтгэл, үр дүн.

## Цар хүрээ

2. **Нягтлан бодох бүртгэлийн аккрузл суурийн дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь энэхүү Стандартыг мөрдөнө.**
3. **Батлагдсан төсвөө олон нийтэд нээлттэй танилцуулах шаардлагатай буюу тийм сонголт хийсэн улсын секторын байгууллагуудад энэ Стандартыг мөрдөнө.**
4. [Хассан]
5. Энэ Стандарт нь батлагдсан төсвийг олон нийтэд нээлттэй танилцуулахыг шаардахгүй, мөн олон нийтэд нээлттэй танилцуулдаггүй, тийм батлагдсан төсвийн талаар санхүүгийн тайлангийн тодруулгын мэдээлэл бэлтгэх буюу төсөвтэй зэрэгцүүлэхийг шаардахгүй.
6. Батлагдсан төсөв нь улсын секторын хяналтанд буй бүх үйл ажиллагааг хамрах байдлаар зарим тохиолдолд зохиогдсон байдаг. Өөр зарим тохиолдолд, засгийн газрын буюу улсын секторын бусад байгууллагын санхүүгийн тайланд тусгасан тодорхой үйл ажиллагаа, бүлэг үйл ажиллагаа буюу байгууллагуудын хувьд тусдаа батлагдсан төсвийг олон нийтэд танилцуулах шаардлагатай байж болох юм. Тухайлбал; (а) засгийн газрын санхүүгийн тайлан нь үйл ажиллагааны хувьд хараат бус бөгөөд өөрсдийн төсвийг бэлтгэдэг тийм засгийн газрын агентлагууд буюу хөтөлбөрүүдийг агуулдаг, эсвэл (б) нийт засгийн газрын зөвхөн үндсэн секторын хувьд төсвийг бэлтгэдэг бол ийм тохиолдол үүсэж болно. Тухайн байгууллагын хувьд батлагдсан төсөв буюу түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг олон нийтэд нээлттэй танилцуулах үедээ санхүүгийн тайлангаа толилуулдаг бүх байгууллагуудын хувьд энэ Стандартыг мөрдөнө.

## Тодорхойлолт

7. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

Нягтлан бодох бүртгэлийн суурь гэдэг нь аккруэл суурьт УСНББОУС болон мөнгөн суурьт УСНББОУС-д тодорхойлсон нягтлан бодох бүртгэлийн аккруэл буюу мөнгөн суурь юм.

Жилийн төсөв гэдэг нь нэг жилийн хувьд батлагдсан төсөв юм. Тухайн төсвийн жилээс хойшхи тайлант үеүдийн хувьд хэвлэн нийтэлсэн хэтийн тооцоолол буюу төсөөлөл нь үүнд хамаарахгүй.

Төсвийн хуваарилалт гэдэг нь хууль тогтоох буюу адилтгах эрх бүхий этгээдийн тусгайлан тодорхойлсон зорилгод зориулан мөнгө санг хуваарилахын тулд хууль тогтоогч байгууллагаас олгосон зөвшөөрөл юм.

Батлагдсан төсөв гэдэг нь хууль, төсвийн хуваарилалтын мэдэгдэл, засгийн газрын тогтоол болон тухайн төсвийн хугацааны урьдчилан төсөөлсөн орлого буюу мөнгөн орлоготой холбоотой бусад шийдвэрээр үүсэх зарлагын эрх юм.

Төсвийн суурь гэдэг нь хууль тогтоогч байгууллагаас баталсан тухайн төсөвт мөрддөг нягтлан бодох бүртгэлийн аккруэл, мөнгөн буюу бусад суурь юм.

Зэрэгцүүлэгдэх суурь гэдэг нь тухайн нэг байгууллагуудын хувьд уг батлагдсан төсөвтэй ижил тайлант үед нэг ижил нягтлан бодох бүртгэлийн суурь болон нэг ижил ангиллын сууриар толилуулсан гүйцэтгэлийн дүн юм.

Тодотгосон төсөв гэдэг нь тухайн төсвийн хугацаанд хамаарах бүх нөөц, өмнөх үеэс шилжиж ирсэн дүн, шилжүүлэг, хуваарилалт, нэмэлт төсвийн хуваарилалт болон бусад зөвшөөрөгдсөн хууль тогтоомжийн буюу адилтгах бүрэн эрхийн дагуу хийгдсэн өөрчлөлтийн хувьд тохируулга хийсэн анхны төсөв юм.

Олон-жилийн төсөв гэдэг нь нэгээс олон жилийн хувьд батлагдсан төсөв юм. Тухайн төсвийн хугацаанаас хойшхи тайлант үеүдийн хувьд хэвлэн нийтэлсэн хэтийн тооцоолол буюу төсөөлөл нь үүнд хамаарахгүй.

Анхны төсөв гэдэг нь тухайн төсвийн хугацааны хувьд анх батлагдсан төсөв юм.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д дахин нийтэлсэн болно.



### **Батлагдсан төсөв**

8. Энэ Стандартад тодорхойлсончлон, батлагдсан төсөв нь одоогийн төлөвлөгөө болон тухайн төсвийн хугацааны туршид урьдчилан төсөөлсөн эдийн засгийн нөхцөл байдал, хууль тогтоох эсвэл бусад холбогдох бүрэн эрх бүхий хууль тогтоогч байгууллагын баталсан зардал буюу зарлагад үндэслэн тэрхүү жилийн эсвэл олон жилийн төсвийн хугацаанд үүсэхээр хүлээгдэж буй урьдчилан төсөөлсөн орлого буюу мөнгөн орлогыг тусгадаг. Батлагдсан төсөв нь гарч тохиолдохоор заавал хүлээгдээгүй ирээдүйн үйл явдлууд болон удирдлагын боломжит үйлдлийн талаархи таамаглалд үндэслэсэн хэтийн тооцоолол буюу төсөөлөл биш юм. Үүнтэй адилаар, батлагдсан төсөв нь прогноз, төсөөлөл эсвэл эдгээрийн хослол, жишээлбэл; нэг жилийн прогноз ба таван жилийн төсөөлөл хэлбэртэй байх хэтийн санхүүгийн мэдээллээс ялгаатай юм.
9. Зарим улс оронд төсвийг батлах үйл явцын нэгэн хэсэг байдлаар тухайн төсвийг хуульчлан баталдаг байж болно. Өөр зарим улс оронд, төсвийг хууль болгохгүйгээр баталдаг байж болох юм. Батлах үйл явц ямар байхаас үл хамааран тухайн батлагдсан төсвийн гол шинж нь тохиролцсон ба тогтоосон зорилгод зориулан засгийн газрын төрийн сан буюу адилтгах байгууллагаас мөнгө санг татан авах эрхийг хууль тогтоогч дээд түвшний байгууллага буюу зохих эрх бүхий бусад байгууллагаас олгох явдал юм. Батлагдсан төсөв нь тусгайлан заасан зүйлсийн хувьд зарлагын эрхийг тогтоодог. Зарлагын эрхийг ерөнхийдөө хууль ёсны хязгаар гэж үздэг бөгөөд байгууллага нь энэхүү хүрээнд үйл ажиллагаагаа явуулах ёстой. Зарим улс орны хувьд, тухайн байгууллагад хариуцуулах батлагдсан төсөв нь анхны төсөв байж болно, харин өөр зарим улс оронд тодотгосон төсөв байж болох юм.
10. Төсвийн хугацаа эхлэхээс өмнө төсвийг батлаагүй бол анхны төсөв нь тухайн төсвийн жилд мөрдөхөөр анх баталсан төсөв байдаг.

### **Анхны болон тодотгосон төсөв**

11. Анхны төсөв нь өмнөх жилүүдээс хуулийн дагуу автоматаар шилжиж ирсэн, төсвийн хуваарилалтын зарцуулагдаагүй үлдэгдлийг агуулсан байж болно. Жишээлбэл; зарим улс оронд засгийн газрын төсөвлөлтийн үйл явц нь өмнөх жилийн амлалтыг биелүүлэхийн тулд өмнөх төсвийн хуваарилалтыг автоматаар дараагийн жилд шилжүүлэхийг шаардсан хуулийн заалттай байдаг. Амлалт нь одоогийн гэрээ хэлцэлд үндэслэсэн ирээдүйн боломжит өр төлбөрийг агуулдаг. Зарим улс оронд амлалтыг үүрэг эсвэл хариуцлага гэж нэрлэдэг бөгөөд бараа, үйлчилгээг хараахан хүлээн аваагүй байх үеийн биелэгдээгүй худалдан авалтын захиалга ба гэрээ нь үүнд хамаардаг.
12. Анхны төсөв нь тухайлбал, дайн байлдаан буюу байгалийн гамшгаас үүдэлтэй зарлагын хэрэгцээ шаардлагуудыг зохих ёсоор хангаж чадахгүй тохиолдолд нэмэлт төсвийн хуваарилалт шаардлагатай байж болох юм.

Түүнчлэн, тайлант үеийн төсөвлөсөн орлого тасалдах ба тухайн төсвийн жилийн туршид санхүүжилтийн тэргүүн ээлжийн эрхийг өөрчлөхийн тулд төсвийн бүрэлдэхүүн хооронд эсвэл төсвийн мөрийн зүйлс хооронд дотоод шилжүүлэлт хийх шаардлагатай байж болно. Иймээс төсвийн сахилга батыг хангахын тулд тухайн тайлант үед анх хуваарилсан дүнгээс уг байгууллага буюу үйл ажиллагаанд хуваарилсан мөнгө санг буцаан багасгах шаардлагатай байж болох юм. Тодотгосон төсөв нь ийм зөвшөөрөгдсөн бүх өөрчлөлт буюу нэмэлт өөрчлөлтийг тусгасан байдаг.

### Гүйцэтгэлийн дүн

13. Төсвийн хэрэгжилтийн үр дүн болох дүнгүүдийг илэрхийлэхийн тулд энэ Стандартад гүйцэтгэл буюу гүйцэтгэлийн дүн гэсэн нэр томъёог ашигласан. Зарим улс оронд, төсвийн төлөвлөгөөний биелэлт, төсвийн хэрэгжилт болон адилтгах нэр томъёог гүйцэтгэл буюу гүйцэтгэлийн дүн гэдэгтэй ижил утгатайгаар ашигладаг байж болох юм.

### Төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлсэн толилуулга

14. **21-р параграфт шаардсанаас бусад тохиолдолд, байгууллага нь олон нийтийн өмнө хариуцах төсвийн дүн ба гүйцэтгэлийн дүн хоорондох зэрэгцүүлэлтийг тусад нь нэмэлт санхүүгийн тайлан байдлаар эсвэл УСНББОУС-ын дагуу одоо толилуулж буй санхүүгийн тайлан дахь төсвийн нэмэлт багана хэлбэрээр толилуулна. Хууль тогтоомжийн хяналтын түвшин бүрийн хувьд төсөв ба гүйцэтгэлийн дүнгийн хоорондох зэрэгцүүлэлтийг тусад нь толилуулна:**
  - (a) **Анхны болон тодотгосон төсвийн дүнгүүд;**
  - (б) **Зэрэгцүүлэгдэх сууриар илэрхийлсэн гүйцэтгэлийн дүнгүүд; ба**
  - (в) **Олон нийтийн өмнө тухайн байгууллагын хариуцдаг төсөв болон гүйцэтгэлийн дүнгийн хоорондох материаллаг зөрүүгийн талаархи тайлбарыг уг санхүүгийн тайлангийн хамтаар гаргаж, олон нийтэд танилцуулдаг бусад баримт бичигт тусган оруулдаг бөгөөд тэдгээр баримт бичигт харилцан лавлагаа үүсгэж, санхүүгийн тайлангийн тодруулгад харуулдагаас бусад тохиолдолд тэмдэглэл тодруулга хэлбэрээр хийх ийм тайлбар.**
15. Анхны болон тодотгосон төсвийн дүнгүүд, түүнчлэн олон нийтэд нээлттэй танилцуулдаг төсөвтэй зэрэгцүүлэгдэх сууриар харуулсан гүйцэтгэлийн дүнгүүдийн санхүүгийн тайлан дахь толилуулга нь нөөцийг уг батлагдсан төсвийн дагуу олж авч, ашиглан зарцуулсан эсэхийг тодорхойлох боломжийг санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгосноор тухайн хариуцлагын циклийг иж бүрэн болгодог. Анхны эсвэл тодотгосон төсөв гэдгээс үл хамааран төсвийн болон гүйцэтгэлийн дүн хоорондох зөрүүг (нягтлан бодох бүртгэлд ихэвчлэн хэлбэлзэл гэж нэрлэдэг) иж бүрэн байдлын зорилгоор санхүүгийн тайланд мөн толилуулж болох юм.
16. Гүйцэтгэлийн дүн ба төсвийн дүнгийн хоорондох материаллаг зөрүүгийн талаархи тайлбар нь олон нийтийн өмнө тухайн байгууллагын хариуцах уг

батлагдсан төсвөөс материаллагаар гажсан шалтгааныг ойлгоход хэрэглэгчдэд тусална.

17. Байгууллага нь өөрийн анхны төсөв, тодотгосон төсөв эсвэл эдгээрийн аль алиныг олон нийтэд нээлттэй танилцуулах шаардлагатай буюу ингэж танилцуулах сонголт хийж болох юм. Анхны болон тодотгосон төсвийн аль алиныг олон нийтэд нээлттэй танилцуулах шаардлагатай тохиолдолд уг анхны төсвийн дүн ба гүйцэтгэлийн дүн хоорондох, эсвэл тодотгосон төсөв ба түүний гүйцэтгэлийн дүн хоорондох материаллаг зөрүүгийн талаархи тайлбарыг 14(в) параграфын дагуу хийх шаардлагатай эсэх талаархи заавар удирдамжийг ихэвчлэн хууль тогтоомж, зохицуулалт буюу бусад эрх бүхий баримт бичигт заасан байдаг. Ийм аливаа заавар удирдамж байхгүй тохиолдолд жишээлбэл, (а) анхны төсөвтэй гүйцэтгэлийг харьцуулахад голлон анхаарахын тулд тэрхүү анхны төсөв ба гүйцэтгэлийн дүн хоорондох зөрүүг, эсвэл (б) тодотгосон төсвийн даган мөрдөлтөнд голлон анхаарахын тулд тодотгосон төсөв ба гүйцэтгэлийн дүн хоорондох зөрүүг лавлагаа болгосноор уг материаллаг зөрүүг тодорхойлж болох юм.
18. Тодотгосон төсөв ба гүйцэтгэлийн дүн нь олон тохиолдолд ижил байдаг. Яагаад гэвэл, төсвийн хэрэгжилтийг тайлант үеийн туршид хянан үнэлдэг бөгөөд тухайн тайлант үед өөрчлөгдөж буй нөхцөл, өөрчлөгдөж буй төлөв байдал болон туршлагыг тусгахын тулд анхны төсвийг явцын дунд хянан засварладаг. Анхны болон тодотгосон төсөв хоорондох өөрчлөлтийн шалтгааны талаархи тайлбарын хувьд тодруулга хийхийг энэ Стандартын 29-р параграфээр шаардсан байдаг. Батлагдсан төсвөө олон нийтэд нээлттэй танилцуулдаг байгууллагууд нь өөрсдийн гүйцэтгэлийг тэдгээр холбогдох батлагдсан төсөвтэй харьцуулж, түүнтэй нийцсэн байдлаар олон нийтэд нээлттэй танилцуулдаг эсэхийг эдгээр тодруулга болон дээрх 14-р параграфээр шаардсан тодруулга нь харуулна.
19. Тайлант үеийн турш дахь уг байгууллагын гүйцэтгэл ба ололт амжилтын талаархи санал мэдэгдэл, үүн дотроо төсвийн дүнгээс гажсан аливаа материаллаг зөрүүгийн тайлбараар хангадаг удирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээ, үйл ажиллагааны тойм мэдээ буюу олон нийтэд танилцуулдаг бусад тайланг ихэвчлэн тухайн санхүүгийн тайлантай хамт гаргадаг. Энэ Стандартын 14(в) параграфт заасанчлан, гүйцэтгэлийн болон төсвийн дүнгүүдийн хоорондох материаллаг зөрүүгийн талаархи тайлбарыг (а) санхүүгийн тайлангийн хамт гаргаж, олон нийтэд танилцуулдаг бусад тайлан буюу баримт бичигт тусган оруулдаг, (б) ийм тайлбарыг хийсэн тайлан буюу баримт бичгийг тухайн санхүүгийн тайланд тодруулдаг байхаас бусад тохиолдолд түүнийг санхүүгийн тайлангийн тодруулгад тусган харуулна.
20. Санхүүгийн тайланд тусган оруулсан зөвхөн зарим байгууллага буюу үйл ажиллагааны хувьд тухайн батлагдсан төсвийг олон нийтэд нээлттэй танилуулдаг тохиолдолд тэрхүү батлагдсан төсөвт тусгасан зөвхөн тэдгээр байгууллага буюу үйл ажиллагаанд 14-р параграфын шаардлагуудыг даган мөрдөнө. Энэ нь тухайлбал, тайлагнагч байгууллага

болох нийт засгийн газрын зөвхөн үндсэн секторын хувьд төсвийг бэлтгэдэг бол 14-р параграфтаар шаардсан тодруулгыг тухайн засгийн газрын зөвхөн үндсэн секторын хувьд хийнэ гэсэн үг юм.

### **Толилуулга ба тодруулга**

21. **Санхүүгийн тайлан ба төсвийг зөвхөн зэрэгцүүлэгдэх сууриар бэлтгэдэг тохиолдолд байгууллага нь төсвийн дүн болон гүйцэтгэлийн дүн хоорондох зэрэгцүүлэлтийг уг үндсэн санхүүгийн тайланд төсвийн нэмэлт багана оруулах байдлаар толилуулна.**
22. Төсвийн болон гүйцэтгэлийн дүнгүүдийн хоорондох зэрэгцүүлэлтийг УСНББОУС 1-д тусгайлан заасанчлан, иж бүрэн санхүүгийн тайланд хамаарах тусдаа санхүүгийн тайлан (Төсөв ба Гүйцэтгэлийн Дүнгүүдийн Зэрэгцүүлэлтийн Тайлан буюу үүнтэй адилтгах нэршил бүхий тайлан)-д толилуулж болно. Өөр нэг хувилбар бол, санхүүгийн тайлан болон төсвийг зэрэгцүүлэгдэх сууриар, өөрөөр хэлбэл тухайн нэг байгууллагын хувьд ижил тайлант үед нэг ижил нягтлан бодох бүртгэлийн сууриар бэлтгэдэг бөгөөд нэг ижил ангиллын бүтцийг мөрддөг тохиолдолд УСНББОУС-ын дагуу толилуулсан одоо байгаа үндсэн санхүүгийн тайланд нэмэлт багана оруулж болох юм. Анхны ба тодотгосон төсвийн дүн, түүнчлэн тухайн байгууллага хүсвэл уг төсвийн болон гүйцэтгэлийн дүнгүүдийн хоорондох зөрүүг эдгээр нэмэлт багананд тусган харуулдаг.
23. Төсөв ба санхүүгийн тайланг зэрэгцүүлэгдэх сууриар бэлтгэдэггүй тохиолдолд Төсөв ба Гүйцэтгэлийн Дүнгүүдийн Зэрэгцүүлэлтийн Тайланг тусад нь толилуулна. Ийм тохиолдолд өөр өөр сууриудаар бэлтгэсэн санхүүгийн мэдээллийг хэрэглэгч нар буруу ойлгохоос сэргийлэхийн тулд төсвийн болон нягтлан бодох бүртгэлийн сууриуд ялгаатай бөгөөд Төсөв ба Гүйцэтгэлийн Дүнгүүдийн Зэрэгцүүлэлтийн Тайланг төсвийн сууриар бэлтгэсэн гэдгийг санхүүгийн тайланд зохих ёсоор тодруулж болох юм.
24. Төсвийг аккруэл сууриар бэлтгэдэг бөгөөд иж бүрэн цогц санхүүгийн тайланг бэлтгэдэг улс орнуудын хувьд, УСНББОУС-аар шаардсан бүх үндсэн санхүүгийн тайланд төсвийн нэмэлт багануудыг оруулж болно. Харин өөр зарим улс орнуудын хувьд, УСНББОУС-д тусгайлан заасан, иж бүрэн цогц санхүүгийн тайлангийн зөвхөн зарим үндсэн санхүүгийн тайлан хэлбэрээр уг аккруэл сууриар бэлтгэсэн төсвийг толилуулж болно. Жишээлбэл; төсвийг санхүүгийн үр дүнгийн тайлан эсвэл мөнгөн гүйлгээний тайлан байдлаар толилуулах бөгөөд нэмэлт мэдээллийг дэмжих хүснэгтэнд харуулж болох юм. Ийм тохиолдолд, төсвийн толилуулгад бас хэрэглэсэн уг үндсэн санхүүгийн тайланд төсвийн нэмэлт багануудыг оруулж болно.

### **Нэгтгэлийн түвшин**

25. Төсвийн баримт бичиг нь тодорхой үйл ажиллагаа, хөтөлбөр буюу байгууллагын талаархи маш дэлгэрэнгүй мэдээллээр хангаж болох юм. Эдгээр дэлгэрэнгүй мэдээллийг тухайн төсвийн үндсэн бүрэлдэхүүний

ерөнхий ангиуд, төсвийн ангилал эсвэл хууль тогтоогч болон бусад эрх бүхий байгууллагад толилуулах ба тэднээр батлуулахад зориулсан төсвийн бүрэлдэхүүнээр ихэвчлэн нэгтгэдэг. Эдгээр ерөнхий ангиуд ба төсвийн бүрэлдэхүүнтэй нийцсэн төсвийн болон гүйцэтгэлийн мэдээллийн тодруулга нь уг төсвийн баримт бичигт тодорхойлсон, хууль тогтоох буюу бусад эрх бүхий байгууллагуудын хяналтын түвшнээр зэрэгцүүлэлтийг хийх боломж бүрдүүлдэг.

26. УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь чанарын шинжүүдийг хангасан мэдээллийг тухайн санхүүгийн тайланд тусгахыг шаарддаг. Үүнд: мэдээлэл нь хэрэглэгчдийн хариуцлагын болон шийдвэр гаргалтын хэрэгцээ шаардлагад хамааралтай бөгөөд уг байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлэх ба бусад чанарын шинжүүдийг хангах, түүнчлэн нийтлэг зорилготой санхүүгийн тайланд тусгасан мэдээллийн хязгаарлагдмал талуудыг харгалзсан байна.
27. Зарим тохиолдолд, батлагдсан төсөвт тусгасан уг дэлгэрэнгүй санхүүгийн мэдээллийг энэ Стандартын шаардлагуудын дагуу санхүүгийн тайланд толилуулахын тулд нэгтгэх шаардлагатай байж болох юм. Мэдээллийн хэт ачаалал үүсгэхээс зайлсхийх ба хууль тогтоох буюу бусад эрх бүхий байгууллагуудын хяналтын холбогдох түвшинг тусгахад ийм нэгтгэл зайлшгүй шаардлагатай байж болно. Нэгтгэлийн түвшинг тодорхойлохдоо мэргэжлийн шүүн тунгаалт хийдэг. Энэ Стандартын зорилгын агуулга, дээрх 26-р параграфт болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлал*-д дурдсан, санхүүгийн тайлагналын чанарын шинжүүдийг харгалзан ийм шүүн тунгаалтыг хийнэ.
28. Төсвийн нэмэлт мэдээлэл, үүн дотроо үйлчилгээний үр дүнгийн талаархи мэдээллийг санхүүгийн тайлангаас өөр бусад баримт бичигт толилуулж болно. Санхүүгийн тайлангаас ийм баримт бичгүүдэд, тухайлбал, төсөв ба гүйцэтгэлийн мэдээллийг тухайн төсвийн санхүүгийн бус мэдээлэлд болон үйлчилгээний үр дүнд харилцан лавлагаа үүсгэхийг дэмжинэ.

#### **Анхны төсвөөс тодотгосон төсөв болгох өөрчлөлт**

29. **Анхны төсөв ба тодотгосон төсвийн хоорондох өөрчлөлт нь тухайн төсвийн доторх дахин хуваарилалтын эсвэл бусад хүчин зүйлсийн үр дагавар эсэх талаархи тайлбарыг уг байгууллага нь дараах байдлаар толилуулна:**
- (а) **Санхүүгийн тайлан дахь тэмдэглэл тодруулга байдлаар; эсвэл**
  - (б) **Санхүүгийн тайланг гаргахаас өмнө, гаргах үед эсвэл түүнтэй хамт гаргасан тайлан илтгэлд оруулах ба тэрхүү тайланд үүсгэсэн харилцан лавлагааг тухайн санхүүгийн тайлангийн тодруулгад тусгах.**

30. Тодотгосон төсөв нь анхны төсвийг хянан засварлах хууль ёсны ажиллагаа буюу бусад олгогдсон бүрэн эрхийн дагуу баталсан бүх өөрчлөлтүүдийг агуулсан байдаг. Энэ Стандартын шаардлагуудын дагуу улсын секторын байгууллага нь анхны төсөв ба тодотгосон төсвийн хоорондох өөрчлөлтийн талаархи тайлбарыг санхүүгийн тайлангийн тодруулгад эсвэл тухайн санхүүгийн тайланг гаргахаас өмнө, гаргах үед эсвэл түүнтэй хамт гаргасан тусдаа тайлан илтгэлд тусгана. Өөрчлөлт нь тухайлбал, анхны төсвийн параметруудийн хүрээнд дахин хуваарилалт хийсний үр дүнд эсвэл төсвийн ерөнхий параметруудийн өөрчлөлт, үүн дотроо засгийн газрын бодлогын өөрчлөлт гэх мэт бусад хүчин зүйлсийн үр дүнд үүссэн эсэхийг уг тайлбарт тусгадаг. Санхүүгийн тайлангийн нэг хэсэг байдлаар биш боловч түүнтэй хамт гаргасан удирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээ буюу үйл ажиллагааны талаархи адилтгах тайланд ийм тодруулгыг ихэвчлэн хийдэг. Төсвийн хэрэгжилтийг тайлагнахын тулд засгийн газраас гаргасан төсвийн үр дүнгийн тайланд ийм тодруулгыг бас хийж болох юм. Тодруулгыг санхүүгийн тайланд бус, харин тусдаа тайланд хийсэн тохиолдолд уг тайлантай холбосон харилцан лавлагааг тухайн санхүүгийн тайлангийн тодруулгад харуулна.

### **Зэрэгцүүлэгдэх суурь**

31. **Төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн хоорондох бүх зэрэгцүүлэлтийг тухайн төсөвтэй зэрэгцүүлэгдэх сууриар толилуулна.**
32. Төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийг тухайн нэг байгууллагуудын хувьд уг батлагдсан төсөвтэй ижил тайлант үед нэг ижил нягтлан бодох бүртгэлийн суурь (аккруэл, мөнгөн буюу бусад суурь) болон нэг ижил ангиллын сууриар толилуулна. Төсвийн даган мөрдөлтийн талаархи санхүүгийн тайлан дахь мэдээллийн тодруулга нь уг төсөвтэй ижил сууриар хийгдсэн гэдгийг энэ нь ханган магадалдаг. Энэ нь төсөв ба гүйцэтгэлийн зэрэгцүүлэлтийг янз бүрийн бүлэг үйл ажиллагааны хувьд нягтлан бодох бүртгэлийн өөр сууриар болон тухайн санхүүгийн тайланд мөрдсөнөөс ялгаатай, толилуулгын буюу ангиллын хэв загвараар зарим тохиолдолд толилуулдаг гэсэн утгыг илэрхийлж болох юм.
33. Санхүүгийн тайлан нь тухайн байгууллагын хяналтанд буй байгууллагууд болон үйл ажиллагааг нэгтгэн тусгадаг. 6-р параграфт дурдсанчлан, тухайн нэгтгэсэн санхүүгийн тайланг бүрдүүлж буй бие даасан байгууллагууд буюу тодорхой үйл ажиллагаануудын хувьд тусдаа төсөв баталж, олон нийтэд нээлттэй танилцуулж болох юм. Ингэж тусдаа төсөв бэлтгэдэг тохиолдолд энэхүү Стандартын шаардлагуудын дагуу тухайн санхүүгийн тайланд толилуулах зорилгоор тэдгээр тусдаа төсвүүдийг дахин нэгтгэн бүрдүүлж болно. Ийм дахин нэгтгэн бүрдүүлэлтийг хийх үедээ уг батлагдсан төсвийн өөрчлөлт буюу хянан засварлалтыг түүнд тусгадаггүй. Яагаад гэвэл, энэ Стандарт нь гүйцэтгэлийн дүнг уг батлагдсан төсвийн дүнтэй зэрэгцүүлэхийг шаарддаг.
34. Байгууллагууд нь өөрсдийн санхүүгийн тайлангийн бэлтгэлт болон батлагдсан төсөвтөө нягтлан бодох бүртгэлийн янз бүрийн сууриудыг

мөрдөж болох юм. Жишээлбэл; засгийн газар нь өөрийн санхүүгийн тайландаа аккруэл суурийг, төсөвтөө мөнгөн суурийг мөрдөж болно. Мөн түүнчлэн, санхүүгийн тайланд хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч, орлого, зардал, цэвэр хөрөнгө/өмчийн бусад өөрчлөлт, мөнгөн гүйлгээг тайлагнадаг боловч төсөв нь ирээдүйд мөнгө санг зарцуулах амлалтууд ба тэдгээр амлалтын өөрчлөлтүүдийн талаархи мэдээлэлд голлон чиглэх буюу түүнийг агуулсан байж болно. Гэхдээ төсөв бэлтгэж буй байгууллага болон санхүүгийн тайлагналын байгууллага нь ихэвчлэн нэг ижил байгууллага байдаг. Үүнтэй адилаар, төсвийг бэлтгэсэн хугацаа болон тухайн төсөвт мөрдсөн ангиллын суурийг санхүүгийн тайланд ихэвчлэн тусгадаг. Энэ нь тухайлбал, уг төсвийн хугацааны туршид төсвийн хэрэгжилтийн явцыг хянан удирдах, түүнчлэн засгийн газар, олон нийт ба бусад хэрэглэгчдэд зохих ёсоор, цаг хугацаанд нь тайлагнах удирдлагын болон хариуцлагын зорилгоор төсөв ба гүйцэтгэлийн мэдээний зэрэгцүүлэлт хийх боломжтой байдлаар санхүүгийн мэдээллийг тухайн нягтлан бодох бүртгэлийн систем бүртгэж, тайлагнаж байгаа гэдгийг ханган магадалдаг.

35. Тухайн санхүүгийн тайланд тусгагдсан байгууллага, үйл ажиллагаанаас өөр байгууллагууд болон үйл ажиллагаануудыг агуулдаг статистикийн тайлагналын системтэй нийцсэн мөнгөн эсвэл аккруэл сууриар зарим улс оронд төсвийг бэлтгэж болох юм. Жишээлбэл; санхүүгийн тайлан нь засгийн газрын хянадаг бүх үйл ажиллагаанууд, үүн дотроо тухайн засгийн газрын бизнесийн үйл ажиллагааны талаар тайлагнадаг бол статистикийн тайлагналын системд нийцүүлэн бэлтгэсэн төсөв нь засгийн газрын үндсэн секторт голлон чиглэдэг бөгөөд өөрийн үндсэн үйл ажиллагаа байдлаар засгийн газрын анхдагч буюу зах зээлийн бус чиг үүргийг зөвхөн биелүүлдэг байгууллагуудыг хамарсан байж болох юм. *УСНББОУС 22, Засгийн Газрын Үндсэн Секторын талаархи Санхүүгийн Мэдээллийн Тодруулга* нь нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийг мөрдсөн ба ийм тодруулга хийхээр сонгосон уг нийт засгийн газрын байгууллагын үндсэн секторын талаархи санхүүгийн мэдээллийн тэмдэглэл тодруулгад хамаарах шаардлагуудыг тусгайлан заадаг. Ихэнх тохиолдолд, УСНББОУС 22-ын дагуу хийсэн тодруулга нь статистикийн тайлагналын загварт тодорхойлсончлон, засгийн газрын үндсэн сектортой нийцсэн байдлаар бэлтгэсэн төсвийн хувьд мөрдсөнтэй нэг ижил байгууллагууд, үйл ажиллагаанууд болон ангиллын сууриудыг хамран тусгасан байдаг. Ийм тохиолдолд, УСНББОУС 22-ын дагуу хийсэн тодруулга нь энэхүү Стандартаар шаардсан тодруулгад бас дэмжлэг үзүүлдэг.
36. Статистикийн тайлагналын загварын хувьд засгийн газрын үндсэн сектор нь үндэсний, мужийн/бүсийн болон орон нутгийн засгийн газрын түвшингүүдээс бүрдэж болох юм. Зарим улс орны хувьд, үндэсний засгийн газар нь (а) мужийн/бүсийн болон орон нутгийн засгийн газруудыг хянадаг, (б) тэдгээр засгийн газруудыг өөрийн санхүүгийн тайландаа нэгтгэдэг, (в) засгийн газрын эдгээр бүх гурван түвшинг агуулдаг уг батлагдсан төсвийг боловсруулж, олон нийтэд нээлттэй танилцуулахыг шаарддаг байж болно. Ийм тохиолдолд, үндэсний засгийн газрын тэдгээр

байгууллагуудын санхүүгийн тайланд энэхүү Стандартын шаардлагуудыг мөрдөнө. Гэвч үндэсний засгийн газар нь мужийн/бүсийн буюу орон нутгийн засгийн газруудыг хянадаггүй тохиолдолд түүний санхүүгийн тайланд мужийн/бүсийн буюу орон нутгийн засгийн газруудыг нэгтгэхгүй. Харин засгийн газрын түвшин тус бүрийн хувьд тусдаа санхүүгийн тайланг бэлтгэдэг. Засгийн газрын байгууллагын хянадаг байгууллагууд болон үйл ажиллагаанууд эсвэл тэдгээрийн дэд хэсгүүдийн хувьд батлагдсан төсвийг олон нийтэд нээлттэй танилцуулдаг зөвхөн тийм тохиолдолд уг засгийн газрын байгууллагын санхүүгийн тайланд энэхүү Стандартын шаардлагуудыг мөрдөнө.

### **Олон-жилийн төсөв**

37. Зарим засгийн газар болон бусад байгууллагууд нь тусдаа жилийн төсвийг биш, харин олон-жилийн төсвийг бэлтгэж, олон нийтэд нээлттэй танилцуулдаг. Уламжлал ёсоор, олон-жилийн төсөв нь хэд хэдэн жилийн төсөв буюу жилийн төсвийн зорилтуудаас бүрддэг. Бүрэлдэхүүн хэсэг болох жилийн тайлант үе бүрийн хувьд батлагдсан төсөв нь уг олон жилийн-төсөвтэй холбоотой төсөвлөлтийн бодлогыг тэрхүү бүрэлдэхүүн тайлант үед хэрхэн мөрдөхийг тусгадаг. Зарим тохиолдолд, олон-жилийн төсөв нь аливаа нэг жилийн хувьд ашиглагдаагүй төсвийн хуваарилалтын дараагийн жилүүд дэх шилжүүлэлтийг харуулдаг.
38. Олон-жилийн төсөв бүхий засгийн газар ба бусад байгууллагууд нь төсвөө хэрхэн баталдагас хамааран өөрсдийн анхны болон тодотгосон төсвөө тодорхойлохдоо янз бүрийн арга хандлагуулыг ашиглаж болох юм. Жишээлбэл; засгийн газар нь хоёр жилийн төсвийг агуулсан хоёр тайлант жилийн төсвийг баталж болох бөгөөд энэ тохиолдолд жил тус бүрийн батлагдсан анхны болон тодотгосон төсвийг тодорхойлох боломжтой байдаг. Хэрэв хоёр жилийн төсвийн эхний жилийн ашиглагдаагүй үлдсэн төсвийн хуваарилалтыг хоёр дахь жилд зарцуулахыг хууль ёсоор зөвшөөрдөг бол энэхүү өмнөх жилээс шилжиж ирсэн дүнгээр уг хоёр дахь жилийн анхны төсвийг нэмэгдүүлнэ. Засгийн газар нь жил тус бүрд хамаарах төсвийн дүнг тусгайлан салган харуулаагүй хоёр буюу бусад олон жилийн төсвийг баталдаг цөөн ховор тохиолдолд энэ Стандартын зорилгоор жилийн төсвийг тодорхойлохдоо, жил тус бүрд аль дүнгүүд хамаарахыг тогтоохын тулд шүүн тунгаалт хийх шаардлагатай байж болох юм. Жишээлбэл; хоёр жилийн төсвийн эхний жилийн хувьд батлагдсан анхны болон тодотгосон төсөв нь эхний жилийн туршид хийгдэх уг хоёр жилийн аливаа батлагдсан капитал худалдан авалт, түүнчлэн тухайн жилд хамааруулж болох дахин давтагдах орлого ба зарлагын зүйлсийн дүнг агуулсан байдаг. Эхний жилээс зарцуулагдаагүй үлдсэн аливаа дүнг дараа нь хоёр дахь жилийн анхны төсөвт оруулах бөгөөд түүний аливаа нэмэлт өөрчлөлтийн хамтаар тухайн төсөв нь тэрхүү хоёр дахь жилийн тодотгосон төсөв болох юм. Олон-жилийн төсвийг хэрэглэдэг тохиолдолд тухайн байгууллага нь уг төсвийн жилийн турш дахь төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн хоорондох уялдаа холбооны талаар нэмэлт тэмдэглэл тодруулга хийхийг дэмжинэ.



## **Төсвийн суурь, хугацаа, цар хүрээний тэмдэглэл тодруулга**

39. **Байгууллага нь уг батлагдсан төсөвт хэрэглэсэн төсөвлөлтийн суурь болон ангиллын суурийг тухайн санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тайлбарлана.**
40. Төсвийг бэлтгэж, толилуулахад ашигласан нягтлан бодох бүртгэлийн суурь (мөнгөн, аккруэл буюу тэдгээрийн зарим сайжруулалт) ба санхүүгийн тайланд ашигласан нягтлан бодох бүртгэлийн суурь нь өөр өөр байж болох юм. Нягтлан бодох бүртгэлийн систем ба төсвийн систем нь мэдээллийг өөр өөр төлөв байдлаас бэлтгэж бүрдүүлдэг тохиолдолд ийм зөрүү үүсэж болно. Тухайлбал; санхүүгийн тайлан нь мөнгөн гүйлгээ болон аккруэл мэдээллийг тайлагнадаг бол төсөв нь мөнгөн гүйлгээнд эсвэл мөнгөн гүйлгээ болон зарим амлалтанд голлон чиглэдэг байж болно.
41. Батлагдсан төсвийг толилуулахад хэрэглэсэн хэлбэр болон ангиллын бүтэц нь санхүүгийн тайланд хэрэглэсэн хэлбэр, загвараас мөн өөр байж болно. Батлагдсан төсөв нь санхүүгийн тайланд хэрэглэсэнтэй ижил сууриар тухайлбал, эдийн засгийн мөн чанараар (ажиллагчдын цалин хөлс, бараа буюу үйлчилгээний зарцуулалт гэх мэт) эсвэл чиг үүргээр (эрүүл мэнд, боловсрол гэх мэт) зүйлсийг ангилж болох юм. Өөр нэг хувилбар бол, төсөв нь тусгай хөтөлбөрөөр (жишээлбэл; ядуурлыг бууруулалт, халдварт өвчний хяналт) эсвэл гүйцэтгэлийн үр дүнгийн зорилтуудтай холбоотой хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдээр (жишээлбэл; дээд боловсролын хөтөлбөрийг төгсөгч оюутнуудаар эсвэл эмнэлгийн яаралтай тусламжийн үйлчилгээгээр хийсэн мэс заслын үйл ажиллагаагаар) зүйлсийг ангилж болох бөгөөд энэ нь санхүүгийн тайланд хэрэглэсэн ангиллаас өөр байдаг. Түүнчлэн, тасралтгүй үйл ажиллагааны (жишээлбэл; боловсрол буюу эрүүл мэнд) дахин давтагдах төсвийг капитал зарлагад (жишээлбэл; дэд бүтэц буюу барилга байгууламж)-д зориулсан капитал төсвөөс тусад нь баталж болох юм.
42. УСНББОУС 1 нь санхүүгийн тайланг бэлтгэх суурь болон мөрдсөн нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын талаархи мэдээллийг тухайн санхүүгийн тайлангийн тодруулгад толилуулахыг байгууллагуудаас шаарддаг. Батлагдсан төсвийг бэлтгэж, толилуулахад мөрдсөн төсөвлөлтийн суурь ба ангиллын суурийн талаархи тодруулга нь уг санхүүгийн тайланд тодруулсан төсвийн болон нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн хоорондох уялдаа холбоог илүү сайн ойлгоход хэрэглэгчдэд тусалдаг.
43. **Байгууллага нь уг батлагдсан төсвийн тайлант хугацааг тухайн санхүүгийн тайлангийн тодруулгад тусгаж тодруулна.**
44. Санхүүгийн тайланг наад зах нь жил бүр бэлтгэж толилуулна. Байгууллагууд нь төсвийг жилээр эсвэл олон-жилээр бэлтгэн баталж болох юм. Батлагдсан төсөвт хамаарах тайлант хугацаа нь санхүүгийн тайланд хэрэглэсэн тайлант хугацаанаас өөр байх тохиолдолд тэрхүү

тайлант хугацааны талаархи тодруулга нь санхүүгийн тайлантай уг төсвийн мэдээ болон төсвийн зэрэгцүүлэлтийн холбогдох уялдаа холбоог тухайн санхүүгийн тайлангийн хэрэглэгч нар илүү сайн ойлгоход тусалдаг. Батлагдсан төсөвт хамаарах тайлант хугацаа нь санхүүгийн тайланд хамрагдах тайлант хугацаатай ижил байх тохиолдолд тэрхүү тайлант хугацааны талаархи тодруулга нь ялангуяа завсрын хугацааны төсөв, санхүүгийн тайлан болон бусад тайлан илтгэлийг бас бэлтгэдэг улс орнуудын хувьд мөн баталгаажуулах чухал үүргийг гүйцэтгэдэг.

45. **Байгууллага нь уг батлагдсан төсөвт хамаарах байгууллагуудыг тухайн санхүүгийн тайлангийн тодруулгад тусган тодорхойлно.**
46. УСНББОУС нь тухайн байгууллагын хяналтанд буй бүх нөөцүүдийг нэгтгэсэн тийм санхүүгийн тайланг бэлтгэж, толилуулахыг байгууллагуудаас шаарддаг. Нийт засгийн газрын түвшинд УСНББОУС-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайлан нь уг засгийн газрын хяналтанд буй төсвөөс хамааралтай байгууллагууд болон улсын секторын худалдаа арилжааны байгууллагуудыг багтаасан байдаг. Гэвч 35-р параграфт тэмдэглэсэнчлэн, статистикийн тайлагналын загварын дагуу бэлтгэдэг, батлагдсан төсөв нь худалдаа арилжааны буюу зах зээлийн сууриар хийгддэг тухайн засгийн газрын үйл ажиллагаануудыг хамруулан тусгаагүй байж болох юм. 31-р параграфын шаардлагуудын дагуу төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийг зэрэгцүүлэгдэх сууриар толилуулна. Төсөвт багтан хамрагдсан байгууллагуудын талаархи тодруулга нь тухайн байгууллагын үйл ажиллагаа тэрхүү батлагдсан төсөвт хамаарах хэмжээ, түүнчлэн уг төсөвт байгууллага нь тэрхүү санхүүгийн тайланд тусгагдсан байгууллагаас ямар ялгаатайг тодорхойлох боломжийг хэрэглэгчдэд олгодог.

### **Зэрэгцүүлэгдэх сууриар тусгасан гүйцэтгэлийн дүн ба санхүүгийн тайлан дахь гүйцэтгэлийн дүнгийн хоорондох тохируулга**

47. Санхүүгийн тайлан ба төсвийг зэрэгцүүлэгдэх сууриар бэлтгэдэггүй тохиолдолд 31-р параграфын дагуу төсөвтэй зэрэгцүүлэгдэх сууриар толилуулсан гүйцэтгэлийн дүнг тухайн санхүүгийн тайланд толилуулсан дараах гүйцэтгэлийн дүнгүүдтэй тохируулж, аливаа суурь, цаг хугацаа болон байгууллагын зөрүүтэй байдлыг тусад нь тодорхойлно:
- (а) Хэрэв төсвийн хувьд аккруэл суурийг хэрэглэдэг бол нийт орлого, нийт зардал, түүнчлэн үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын ажиллагааны болон санхүүгийн ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ; эсвэл
  - (б) Хэрэв төсвийн хувьд аккруэл сууриас өөр суурийг хэрэглэдэг бол үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын ажиллагааны болон санхүүгийн ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ

**Уг тохируулгыг төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийн тайланд эсвэл санхүүгийн тайлангийн тодруулга хэсэгт тусгаж тодруулна.**

48. Зэрэгцүүлэгдэх суурьтай нийцүүлэн тодорхойлсон гүйцэтгэлийн дүн ба санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн гүйцэтгэлийн дүнгийн хоорондох зөрүүг дараах байдлаар зохих ёсоор ангилж болно:
- (а) Суурийн зөрүү, энэ нь уг батлагдсан төсвийг нягтлан бодох бүртгэлийн сууриас өөр сууриар бэлтгэсэн үед үүсдэг. Жишээлбэл; төсвийг мөнгөн сууриар эсвэл тохируулсан мөнгөн сууриар бэлтгэдэг, харин санхүүгийн тайланг аккруэл сууриар бэлтгэдэг байх;
  - (б) Цаг хугацааны зөрүү, энэ нь тухайн санхүүгийн тайланд тусгасан тайлант хугацаанаас уг төсвийн тайлант хугацаа өөр байх үед үүсдэг; ба
  - (в) Байгууллагын зөрүү, энэ нь санхүүгийн тайланг бэлтгэж буй тухайн байгууллагын нэг хэсэг болох байгууллагууд эсвэл хөтөлбөрүүдийг төсөвт тусгахгүй байх тохиолдолд үүсдэг.

Мөн санхүүгийн тайлангийн болон төсвийн толилуулгын хувьд хэрэглэсэн хэлбэр загвар ангиллын бүтцийн хувьд зөрүүтэй байж болох юм.

49. Энэ Стандартын 47-р параграфтаар шаардсан тохируулга нь төсвийн сууриар илэрхийлсэн гүйцэтгэлийн дүн ба санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүнгийн хоорондох зөрүүгийн гол эх үүсвэрүүдийг тогтоосноор өөрийн хариуцлагын үүргийг илүү сайн биелүүлэх боломжийг тухайн байгууллагад олгодог. Төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтэнд толилуулсан гол нийт дүн болон дэд дүн нэг бүрийг эсвэл зүйлсийн анги тус бүрийг тухайн санхүүгийн тайлан дахь адилтгах дүнгүүдтэй тохируулахыг энэ Стандартаар хориглодоггүй.
50. Төсвийн баримт бичиг ба санхүүгийн тайлангийн аль алиныг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн нэг ижил суурийг мөрддөг зарим байгууллагуудын хувьд зөвхөн уг төсвийн хэрэгжилтийн дүн ба санхүүгийн тайлан дахь адилтгах дүнгийн хоорондох зөрүүг тодорхойлохыг шаарддаг. (а) Төсвийг нэг ижил хугацаагаар бэлтгэдэг, (б) төсөв нь нэг ижил байгууллагуудыг агуулсан байдаг, (в) санхүүгийн тайлантай ижил толилуулгын хэлбэр загварыг ашигладаг бол ийм тохиолдол үүсдэг. Ийм тохиолдолд тохируулга хийх шаардлагагүй байдаг. Төсөв болон санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нэг ижил суурийг мөрддөг өөр бусад байгууллагуудын хувьд толилуулгын хэлбэр загвар, тайлагнагч байгууллага эсвэл тайлант үе нь өөр өөр байж болно. Жишээлбэл; тухайн батлагдсан төсөв нь санхүүгийн тайлангаас өөр ангилал буюу толилуулгын хэлбэр загварыг мөрддөг, уг байгууллагын зөвхөн худалдаа арилжааны бус үйл ажиллагааг тусгадаг эсвэл олон жилийн төсөв байж болно. Нягтлан бодох бүртгэлийн нэг ижил сууриар бэлтгэдэг төсөв ба санхүүгийн тайлангийн хооронд толилуулгын, цаг хугацааны эсвэл

байгууллагын зөрүүтэй тохиолдолд ийм тохируулга хийх нь зайлшгүй шаардлагатай юм.

51. Батлагдсан төсвийн толилуулгад нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийг (эсвэл тохируулсан мөнгөн суурийг буюу тохируулсан аккруэл суурийг), харин санхүүгийн тайланд аккруэл суурийг ашигладаг байгууллагуудын хувьд төсөв ба гүйцэтгэлийн зэрэгцүүлэлтийн тайланд толилуулсан гол нийт дүнгүүдийг УСНББОУС 2, *Мөнгөн Гүйлгээний Тайлан*-гийн дагуу бэлтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд толилуулсан үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ, хөрөнгө оруулалтын ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ, санхүүгийн ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээтэй тохируулна.
52. **Өмнөх тайлант үеийн хувьд энэ Стандартын шаардлагуудын дагуу зэрэгцүүлэгдэх мэдээллийн тодруулга хийх шаардлагагүй юм.**
53. Батлагдсан төсвөө олон нийтэд нээлттэй танилцуулдаг байгууллагуудын санхүүгийн тайланд төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийг тусгахыг энэ Стандартаар шаарддаг. Энэ Стандарт нь өмнөх тайлант үеийн гүйцэтгэлийг тэрхүү өмнөх тайлант үеийн төсөвтэй зэрэгцүүлсэн тодруулга хийхийг шаарддаггүй, мөн уг өмнөх тайлант үеийн гүйцэтгэл ба төсвийн хоорондох зөрүүгийн талаархи холбогдох тайлбаруудыг тухайн тайлант үеийн санхүүгийн тайланд тодруулахыг шаарддаггүй.

### **Хүчин төгөлдөр болох хугацаа**

54. **Байгууллага нь энэхүү Стандартыг 2009 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2009 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.**
- 54А. **2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-ийн үр дүнд 55-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед УСНББОУС 33-ыг мөрдсөн бол уг нэмэлт өөрчлөлтийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.**
- 54Б. **2016 оны 4 дүгээр сард гаргасан УСНББОУС 2015-ын *Сайжруулалтууд*-аар 26-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг**

зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.

- 54В. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 4-р параграфыг хасаж, 3 ба 46-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
55. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

## Дүгнэлтийн Үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 24-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### Стандартын цар хүрээ

- ДҮ1. УСНББОУС3-ийн СТОУС-тай нийцүүлэх хөтөлбөр нь УСНББОУС3-ийн ажлын хөтөлбөрийн чухал элемент юм. УСНББОУС3-ийн бодлого нь улсын секторын байгууллагуудад тохиромжтой тохиолдолд НББОУС3-өөс гаргасан СТОУС-тай аккруэл суурьт УСНББОУС-ыг нийцүүлэх явдал юм.
- ДҮ2. Засгийн газар эсвэл засгийн газрын тодорхой байгууллага эсэхээс үл хамааран улсын секторын байгууллагууд нь өөрийн хариуцах батлагдсан төсвөө олон нийтэд нээлттэй танилцуулахыг олон улс оронд хууль тогтоомж болон бусад бүрэн эрхээр шаарддаг. Засгийн газрын ил тод, тунгалаг байдалд ийм тодруулга шаардлагатай байдаг. Зарим тохиолдолд ийм хууль тогтоомж болон бүрэн эрхэд захирагддаггүй засгийн газар эсвэл засгийн газрын байгууллага нь өөрийн батлагдсан төсвийг олон нийтэд нээлттэй танилцуулах сонголтыг сайн дураараа хийж болох юм. Өөрийн хариуцах батлагдсан төсвөө олон нийтэд нээлттэй танилцуулдаг засгийн газрууд болон засгийн газрын байгууллагуудад энэ Стандартыг мөрдөнө.
- ДҮ3. Батлагдсан төсөв нь засгийн газрын буюу бусад байгууллагын ирээдүйн тайлант үеийн төлөвлөгөөний санхүүгийн онцлог шинжүүдийг тусгадаг бөгөөд засгийн газрын төсвөөс санхүүждэг үйл ажиллагааны хувьд уг мөнгө санг зарцуулах эрхийг илэрхийлдэг. Төсвийн хэрэгжилтийн үр дүнг эдгээр санхүүгийн төлөвлөгөөтэй харьцуулан тайлагнах нь санхүүгийн тайлангийн ил тод байдлыг нэмэгдүүлэх бөгөөд өөрийн төсвөө олон нийтэд нээлттэй танилцуулах шаардлагатай эсвэл тэгэх сонголт хийсэн байгууллагын хариуцлагын үүргийн биелэлтийн чухал элемент юм. Төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийг санхүүгийн тайланд тусган оруулах нь мөнгө санхүүжилтийг урьдчилан таамагласны дагуу босгон бүрдүүлсэн бөгөөд хууль тогтоогч буюу бусад эрх бүхий байгууллагын баталсан төсвийн дагуу ашиглан зарцуулсан эсэхийг үнэлэхэд хэрэглэгчдэд туслах санхүүгийн мэдээллээр хангадаг. Төсвийн хэрэгжилтийн үр дүн болох дүнгүүдийг илэрхийлэхийн тулд энэ Стандартад гүйцэтгэл буюу гүйцэтгэлийн дүн гэсэн нэр томъёог ашигласан. Зарим улс оронд, төсвийн төлөвлөгөөний биелэлт, төсвийн хэрэгжилт болон адилтгах нэр томъёог гүйцэтгэл буюу гүйцэтгэлийн дүн гэдэгтэй ижил утгатайгаар ашигладаг байж болох юм.
- ДҮ4. Өөрсдийн батлагдсан төсвөө олон нийтэд нээлттэй танилцуулдаг олон засгийн газрууд болон засгийн газрын байгууллагууд нь төсөвтэй харьцуулсан гүйцэтгэлийн дүнгээ санхүүгийн тайландаа угаасаа тайлагнасан байдаг. Мөн тэд төсөв ба гүйцэтгэлийн хоорондох материаллаг зөрүүгийн талаархи тайлбарыг дараах байдлаар тусгадаг: (а) санхүүгийн тайлангийн тодруулгад, эсвэл (б) удирдлагын хэлэлцүүлэг

ба дүн шинжилгээ буюу үүнтэй адилтгах тайлан илтгэлд, эсвэл (в) өөрсдийн санхүүгийн тайлангийн хамтаар гаргадаг төсвийн төлөвлөгөөний биелэлт буюу адилтгах тайлан илтгэлд. Ийм засгийн газар болон засгийн газрын байгууллагуудын хувьд, төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийг хууль тогтоогч буюу адилтгах эрх бүхий байгууллагын баталсан хяналтын түвшингүүдээр ерөнхийдөө харуулдаг бөгөөд төсвийн эрхийг хэтрүүлсэн тохиолдолд материаллаг зөрүүгийн талаархи тайлбарыг хийдэг. УСНББОУСЗ-ийн үзэл бодлоор бол ийм практик нь тохиромжтой бөгөөд уг практикыг албан ёсны болгох, түүнчлэн өөрсдийн батлагдсан төсвөө олон нийтэд нээлттэй танилцуулдаг бүх байгууллагууд үүнийг даган мөрдөхийг шаардахын тулд энэхүү Стандартыг гаргасан.

ДҮ5. Энэ Стандарт нь өөрсдийн батлагдсан төсвөө олон нийтэд нээлттэй танилцуулахыг байгууллагуудаас шаарддаггүй буюу олон нийтэд нээлттэй танилцуулах тухайн батлагдсан төсвийн хувьд толилуулгын шаардлагуудыг тусгайлан заадаггүй. Ингэх нь энэ Стандартын цар хүрээнээс давсан асуудал болох юм. Гэвч эдгээр асуудлуудыг зохицуулах УСНББОУС-ыг боловсруулах хэрэгтэй эсэхийг ирээдүйд авч үзнэ гэдгээ УСНББОУСЗ мэдэгдсэн.

### **Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын хэрэгцээ шаардлага**

ДҮ6. Санхүүгийн тайлан нь тухайн байгууллагын дараах үүргийг ханган биелүүлэхэд зориулагдсан мэдээллийн толилуулгыг тусган агуулах зорилготой гэж УСНББОУС 1-д тайлбарласан байдаг: (а) байгууллагын санхүүгийн байдал, үр дүн, мөнгөн гүйлгээ зэрэг асуудлуудыг хариуцах, (б) байгууллагын үр дүнг түүний үйлчилгээний өртөг зардал, үр ашиг, биелэлтээр үнэлэхэд ач холбогдолтой мэдээллээр хангах. Мөн санхүүгийн тайлагнал нь тухайлбал, хууль ёсоор баталсан төсвөө уг байгууллага даган мөрдсөн талаархи мэдээллээр хэрэглэгчдийг хангаж болох юм.

ДҮ7. Энэ Стандартыг гаргахаас өмнө, УСНББОУС 1 нь санхүүгийн тайлан ба төсвийг нэг ижил сууриар бэлтгэсэн тохиолдолд тэдгээр төсвийн болон гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийг тухайн санхүүгийн тайланд тусган оруулахыг дэмждэг боловч заавал шаарддаггүй байсан. Гэвч зарим тохиолдолд байгууллага нь санхүүгийн тайлангаас өөр сууриар бэлтгэж, толилуулсан уг батлагдсан төсвөө олон нийтэд нээлттэй танилцуулах, түүнчлэн гүйцэтгэл ба төсвийн зэрэгцүүлэлтийг тухайн санхүүгийн тайланд тусган оруулах сонголт хийж болох юм. Ийм нөхцөл байдалд тодруулга хийх дэлгэрэнгүй зүйлс болон толилуулгын арга маягийн талаархи заавар удирдамжийг УСНББОУС 1-д тусгайлан заагаагүй. УСНББОУСЗ-ийн үзэл бодлоор бол ийм нөхцөл байдлыг УСНББОУС-уудад авч үзэх хэрэгтэй юм.

ДҮ8. Байгууллага нь өөрийн батлагдсан төсвөө олон нийтэд нээлттэй танилцуулах шаардлагатай буюу ингэх сонголт хийсэн тохиолдолд энэ

Стандартыг мөрдөнө. Энэ тохиолдолд УСНББОУСЗ-ийн үзэл бодлоор бол тухайн байгууллага өөрийн гүйцэтгэлийг төсөвтэй нийцүүлж, түүний дагуу байлгах хариуцлагыг олон нийтийн өмнө хүлээнэ гэдэг нь хууль тогтоогч буюу бусад эрх бүхий байгууллагын санаа зорилго болон үр нөлөө, түүнчлэн уг байгууллагын өөрийн сайн дурын үйлдлээр ойлгомжтой, тодорхой байдаг. Мөн УСНББОУСЗ-ийн үзэл бодлоор бол, төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн талаархи мэдээллийн тодруулга нь ийм байгууллагуудын хариуцлагын биелэлтийн зайлшгүй шаардлагатай элемент бөгөөд санхүүгийн тайланд зохих тодруулгыг хийсэн гэдгийг ханган магадлах шаардлагыг УСНББОУС-д тусган оруулах хэрэгтэй байдаг.

ДҮ9. Санхүүгийн тайлан болон төсвийг нэг ижил сууриар бэлтгэдэг тохиолдолд гүйцэтгэл ба төсвийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийн тодруулгад энэ Стандартын шаардлагуудыг даган мөрдөх нь өөрийн гүйцэтгэлийн хувьд тухайн байгууллагын хүлээх хариуцлагын биелэлтийг улам бүр нэмэгдүүлж өгдөг. Санхүүгийн тайлан болон төсвийг өөр өөр сууриар бэлтгэдэг тохиолдолд энэ Стандартын шаардлагуудыг даган мөрдөх нь уг байгууллага батлагдсан төсвөө даган мөрдөх өөрийн хариуцлагыг биелүүлэхэд тухайн санхүүгийн тайлангийн гүйцэтгэх үүргийг улам бүр нэмэгдүүлж өгдөг.

ДҮ10. [УҮГ]-аас (2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргаснаас хойш ийм дөрвөлжин хаалтанд тусгасан нэр томъёог цаашид ашиглахаа больсон) бусад улсын секторын бүх байгууллагууд нь өөрсдийн батлагдсан төсвөө олон нийтэд нээлттэй танилцуулах ба энэ Стандартын шаардлагуудыг даган мөрдөхийг тэднээс шаардах эсвэл ингэхийг дэмжих эсэхийг УСНББОУСЗ нь энэ Стандартыг гаргах үедээ харгалзан үзсэн. УСНББОУСЗ нь батлагдсан төсвийг олон нийтэд нээлттэй байлгах эсэхийг энэ Стандартад тусгайлан заах зорилгогүй гэдгийг онцлон тэмдэглэсэн бөгөөд байгууллагуудад ийм шаардлага тавихгүй буюу төсвийн тайлагналд зориулсан шаардлагуудыг боловсруулахад түүний гүйцэтгэх үүргийг цаашид харгалзан үзэх хүртэл одоогийн төлөв байдалд нэмэлт оруулахгүй байхыг зөвшөөрсөн. Батлагдсан төсвөө олон нийтэд нээлттэй танилцуулдаггүй улсын секторын байгууллагууд нь энэ Стандартын шаардлагуудыг мөрдөх сонголт хийсэн бол ингэж мөрдөхийг хориглохгүй гэдгээ УСНББОУСЗ мөн онцлон тэмдэглэсэн.

### **Батлагдсан төсөвтэй зэрэгцүүлэлт**

ДҮ11. Энэ Стандарт нь анхны ба батлагдсан төсвийн дүнгүүдийн, түүнчлэн төсвийн дүнгүүдтэй зэрэгцүүлэгдэх сууриар илэрхийлсэн гүйцэтгэлийн дүнгүүдийн тодруулга хийхийг шаарддаг. Энэ нь УСНББОУС 1-д тодорхойлсон, хариуцлагатай байдлын нийцлийн бүрэлдэхүүн хэсгийн хэрэгжилтийг хангадаг. Санхүүгийн тайлангийн хэрэглэгчид нь тодруулга хийсэн хууль тогтоох байгууллагын хяналтын түвшин тус бүрийн хувьд батлагдсан анхны ба/буюу тодотгосон төсвийн дүнгүүд болон тэдгээрийн адилтгах гүйцэтгэлийн дүнгүүдийн хоорондох зөрүүг (нягтлан бодох



бүртгэлд ихэвчлэн “хэлбэлзэл” гэж нэрлэдэг) тогтоох ба тодорхойлох боломжтой байдаг.

- ДҮ12. Гүйцэтгэл ба төсвийн дүнгүүдийн хоорондох материаллаг зөрүүгийн (зэрэг эсвэл сөрөг эсэхээс үл хамааран) талаархи тайлбарыг санхүүгийн тайлантай хамт гаргадаг, олон нийтэд нээлттэй бусад баримт бичигт тусган оруулдаг байхаас бусад тохиолдолд энэ Стандарт нь ийм тайлбарыг уг санхүүгийн тайлангийн тэмдэглэл тодруулга байдлаар тусгахыг шаарддаг. УСНББОУСЗ-ийн үзэл бодлоор бол ийм мэдээллийн тодруулга нь санхүүгийн тайлангийн ил тод, ойлгомжтой байдлыг нэмэгдүүлж, төсвөө олон нийтэд нээлттэй танилцуулдаг байгууллагуудын хариуцлагатай байдлыг бэхжүүлж өгдөг. Ийм зөрүүгийн тайлбарыг тухайн санхүүгийн тайлантай хамт гаргасан удирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээ, үйл ажиллагааны тойм мэдээ, төсвийн төлөвлөгөөний биелэлт буюу адилтгах тайланд тусгаж болох юм. УСНББОУСЗ-ийн үзэл бодлоор бол, уг тайлбарыг ийм тайлан илтгэлд тусган оруулсан тохиолдолд санхүүгийн тайланд давтан илэрхийлэх шаардлагагүй, харин санхүүгийн тайлангийн тодруулга нь хэрэглэгчдийг тэдгээр тайлан илтгэлд чиглүүлж өгдөг.

### **Анхны болон тодотгосон төсвийн тодруулга**

- ДҮ13. Төсвийг тухайн тайлант үеэс өмнө бэлтгэдэг бөгөөд байгалийн гамшгийн тохиолдол, улс төрийн буюу эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлт нь уг анхны батлагдсан төсөвт тухайн төсвийн хугацааны туршид засвар өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагыг үүсгэж болох юм. Зарим улс орны хувьд, ийм засвар өөрчлөлтийг (тусгайлан заасан хязгаарын дотор) хийх бүрэн эрхийг Сангийн Сайд буюу адилтгах эрх бүхий албан тушаалтанд олгодог. Харин зарим улс орны хувьд ийм засвар өөрчлөлтийг хууль тогтоогч байгууллагаар батлуулах шаардлагатай байдаг. Ийм засвар өөрчлөлтийг зохих эрх бүхий этгээд зөвшөөрөн баталсан тохиолдолд энэ нь тухайн тайлант үеийн тодотгосон төсвийн бүрэлдэхүүн болдог. УСНББОУСЗ-ийн үзэл бодлоор бол, анхны болон тодотгосон төсвийн тодруулга нь тухайн тайлант үеийн туршид зөвшөөрөн батлагдаж, уг анхны төсөвт оруулсан өөрчлөлтийн шинж төрөл ба хэмжээг санхүүгийн тайлангийн хэрэглэгч нар мэдэж байгаа гэдгийг ханган магадлахад зайлшгүй шаардлагатай байдаг.
- ДҮ14. Тухайн тайлант үеийн туршид хийгдсэн бодлогын өөрчлөлт, үүн дотроо засгийн газрын тэргүүн ээлжинд ач холбогдол зүйлсийн өөрчлөлт эсвэл урьдчилан таамаглаагүй эдийн засгийн нөхцөл байдлын үр дүнд уг анхны төсөвт засвар өөрчлөлт оруулж болох юм. УСНББОУСЗ-ийн үзэл бодлоор бол, анхны ба тодотгосон төсвийн хоорондох өөрчлөлт нь уг төсвийн хүрэн дэх дахин хуваарилалтын эсвэл бусад хүчин зүйлсийн үр дүн эсэхээс үл хамааран тухайн тайлант үеийн туршид анхны болон тодотгосон төсвийн хооронд гарсан өөрчлөлтийн учир шалтгааны талаархи тайлбарын тодруулга нь хариуцлагатай байдлын үүргээ биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай бөгөөд эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлт ба бодлогын өөрчлөлтийн санхүүгийн үр нөлөөний дүн

шинжилгээний хувьд чухал ач холбогдолтой орц мэдээллээр хангадаг. Уг тайлбарыг санхүүгийн тайлангийн тодруулгад эсвэл тухайн санхүүгийн тайланг гаргахаас өмнө, гаргах үед эсвэл түүнтэй хамт гаргасан тайлан илтгэлд тусган оруулж болно. Төсвийн хэлбэлзлийн тайлбарын хувьд дээр дурдсантай адилаар, УСНББОУСЗ-ийн үзэл бодлоор бол, уг тайлбарыг ийм тайлан илтгэлд тусган оруулсан тохиолдолд санхүүгийн тайланд давтан илэрхийлэх шаардлагагүй, харин санхүүгийн тайлангийн тодруулга нь хэрэглэгчдийг тэдгээр тайлан илтгэлд чиглүүлж өгдөг.

### **Төсвийн суурийн мөрдөлт, төсөв ба нягтлан бодох бүртгэлийн сууриудын тохируулга**

ДҮ15. Байгуулагууд нь өөрсдийн санхүүгийн тайлан болон батлагдсан төсвөө бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн өөр өөр сууриудыг мөрддөг байж болох юм. Тухайлбал; санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийг мөрддөг зарим байгууллага нь төсвөө мөнгөн сууриар бэлтгэдэг байж болно. Төсөвлөлтийн суурь ба санхүүгийн тайлангийн хоорондох зөрүү нь мөн цаг хугацааны, байгууллагын буюу ангиллын зөрүүтэй байдлын улмаас үүсэж болох юм.

ДҮ16. Энэ Стандарт нь төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийг тухайн нэг байгууллагуудын хувьд уг батлагдсан төсөвтэй ижил тайлант үед нэг ижил сууриар (хэлбэр загвар, нэр томъёо, төсөвлөлтийн суурь, ангилал) толилуулахыг шаарддаг. Энэ нь хууль ёсоор зөвшөөрөн батлагдсан төсвийн дагуу уг гүйцэтгэлийн дүнгүүдийг ашиглан зарцуулсан хэмжээг илтгэн харуулах боломжийг тухайн санхүүгийн тайланд олгоход зайлшгүй шаардлагатай байдаг. Энэ нь тодруулгыг зэрэгцүүлэгдэх сууриар хийсэн эсэх, батлагдсан төсвийн даган мөрдөлтийг санхүүгийн тайлангаар илтгэн харуулсан эсэхийг ханган магадалдаг. Иймээс суурийн, цаг хугацааны, байгууллагын хувьд зөрүүтэй байх тохиолдолд уг батлагдсан төсөвтэй зэрэгцүүлэгдэх боломжтой болгохын тулд тухайн санхүүгийн тайланд тусгасан дүнгүүдийг дахин өөрчлөх шаардлагатай байдаг.

ДҮ17. Санхүүгийн тайлан ба төсвийг зэрэгцүүлэгдэх сууриар бэлтгэдэггүй тохиолдолд төсөв ба санхүүгийн тайлангийн хоорондох уялдаа холбоог илүү сайн тогтоох боломжийг хэрэглэгчдэд олгохын тулд энэ Стандарт нь төсвийн сууриар илэрхийлсэн гүйцэтгэлийн дүнгүүдийг уг санхүүгийн тайланд толилуусан, тухайн тодорхой адилтгах дүнгүүдтэй тохируулах ба аливаа суурийн, цаг хугацааны, байгууллагын зөрүүтэй байдлыг тусад нь тодорхойлохыг шаарддаг. Хэрэв төсөв ба санхүүгийн тайланг нэг ижил сууриар бэлтгэдэг бол зөрүүгийн тохируулга шаардлагагүй юм.

### **Төсөв ба гүйцэтгэлийн мэдээллийн толилуулга**

ДҮ18. Энэ Стандарт нь төсөв ба гүйцэтгэлийн мэдээллийг тусдаа тайланд толилуулахыг зөвшөөрдөг, харин төсөв болон санхүүгийн тайланг зэрэгцүүлэгдэх сууриар бэлтгэдэг зөвхөн тийм тохиолдолд одоогийн санхүүгийн тайланд оруулсан төсвийн нэмэлт багана байдлаар

толилуулахыг зөвшөөрдөг. Толилуулгын аргын уян хатан байдал нь санхүүгийн тайланд тусган оруулахын ач холбогдлыг хадгалахын зэрэгцээгээр хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад хамгийн сайнаар үйлчлэх тийм арга замаар зэрэгцүүлэлтийг толилуулах боломжийг байгууллагуудад олгодог. Санхүүгийн тайлан болон төсвийг нягтлан бодох бүртгэлийн өөр өөр сууриар бэлтгэдэг тохиолдолд толилуулгын зорилгоор нэмэлт багана оруулах хандлагыг хязгаарлан хориглох нь зэрэгцүүлэгдэх сууриар уг төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийг толилуулсан эсэхийг ханган магадлахад зайлшгүй шаардлагатай байдаг.

### **Анх мөрдөлт**

ДҮ19. УСНББОУСЗ нь энэ Стандартыг 2006 оны 12 дугаар сард гаргасан. 2009 оны 01 сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үе хүртэл энэ Стандартыг анх удаа мөрдөхийг шаардаагүй. Мөрдөх хугацааны ингэж хойшлуулалт нь өөрсдийн төсөв ба санхүүгийн тайлагналын горимуудыг боловсруулах, түүнчлэн тэдгээр горим, тайлант үе болон хамрах хугацааг тохиромжтой байдлаар уялдуулах хангалттай цаг хугацааг байгууллагуудад олгох зорилготой байсан. Энэ Стандартыг дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө.

ДҮ20. УСНББОУСЗ нь УСНББОУС-уудыг анх мөрдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд энэ Стандартыг мөрдөхөөс чөлөөлөх эсэх талаар бас авч үзсэн бөгөөд ингэж чөлөөлөх шаардлагагүй гэж шийдвэрлэсэн. Яагаад гэвэл, байгууллагууд нь бүх УСНББОУС-уудыг анх мөрдөх цаг хугацаандаа энэ Стандартын шаардлагуудыг харгалзан үнэлж, хүчин зүйл болгон тусган оруулах юм.

### **Зэрэгцүүлсэн дүнгүүдийг тодруулах шаардлагаас чөлөөлөлт**

ДҮ21. Энэ Стандарт нь өмнөх тайлант үеийн гүйцэтгэлийг тэрхүү өмнөх тайлант үеийн төсөвтэй зэрэгцүүлсэн тодруулгыг одоогийн тайлант үеийн санхүүгийн тайланд тусган оруулахыг шаарддаггүй, мөн уг өмнөх тайлант үеийн гүйцэтгэл ба төсвийн хоорондох зөрүүгийн талаархи холбогдох тайлбаруудыг тухайн одоогийн тайлант үеийн санхүүгийн тайланд тодруулахыг шаарддаггүй.

ДҮ22. Энэ Стандартын гол анхаарах зүйл нь батлагдсан төсвөө тухайн тайлант үеийн туршид даган мөрдөх өөрийн хариуцлагатай байдлын үүргээ уг байгууллага биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх явдал байдаг. Энэ Стандартаар шаардсан олон тайлбар тодруулгыг тухайн санхүүгийн тайлангийн нэг хэсэг байдлаар биш боловч түүнтэй хамт гаргасан бусад баримт бичгүүдэд тусгаж болох юм. Зэрэгцүүлэгдэх мэдээллийн тодруулгын шаардлагууд нь мэдээллийн хэт төвлөрөл үүсгэх ба тайлагналын шаардлагуудын хэт нарийн цогц сүлжээ бий болгох, ингэснээр санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн ашиг сонирхолд нийцэхгүй болох эсэхэд УСНББОУСЗ нь анхаарал хандуулдаг.

**2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУСЗ-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 24-д хийсэн хянан засварлалт**

ДҮ23. УСНББОУСЗ нь 2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (a) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р* параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

## Үлгэрчилсэн жишээ

Энэхүү Үлгэрчилсэн жишээ нь УСНББОУС 24-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

### Төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлэлтийн тайлан

“ХХ” засгийн газрын 20XX оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жил

#### Мөнгөн сууриар бэлтгэсэн төсөв

#### (Чиг үүргээр харуулсан төлбөрийн ангилал)

Тэмдэглэл: Төсөв ба нягтлан бодох бүртгэлийн суурь нь өөр байна. Энэхүү Төсөв ба Гүйцэтгэлийн Дүнгүүдийн Зэрэгцүүлэлтийн Тайланг уг төсвийн сууриар бэлтгэсэн.

	Төсөвлөсөн дүнгүүд		Зэрэгцүүлэг дэх сууриар илэрхийлсэн гүйцэтгэлийн дүн	Тодотгосон төсөв ба гүйцэтгэлийн хоорондох зөрүү*
	Анхны	Тодотгосон		
(Тооцооны нэгжээр)				
<b>ОРЛОГО</b>				
Татвар	X	X	X	X
Тусламжийн гэрээ				
Олон улсын агентлаг	X	X	X	X
Бусад буцалтгүй тусламж ба туслалцаа	X	X	X	X
Орлого: Зээллэг	X	X	X	X
Орлого: Үндсэн хөрөнгийн данснаас хасалт	X	X	X	X
Худалдааны үйл ажиллагаа	X	X	X	X
Бусад орлого	X	X	X	X
<b>Нийт орлого</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>
<b>ТӨЛБӨР</b>				
Эрүүл мэнд	(X)	(X)	(X)	(X)
Боловсрол	(X)	(X)	(X)	(X)
Нийгмийн хэв журам/аюулгүй байдал	(X)	(X)	(X)	(X)
Нийгмийн хамгаалал	(X)	(X)	(X)	(X)
Батлан хамгаалах	(X)	(X)	(X)	(X)
Орон сууц, нийтийн аж ахуй	(X)	(X)	(X)	(X)
Амралт, соёл, шашин	(X)	(X)	(X)	(X)
Эдийн засгийн асуудал	(X)	(X)	(X)	(X)
Бусад	(X)	(X)	(X)	(X)
<b>Нийт төлбөр</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>
<b>ЦЭВЭР ОРЛОГО (ТӨЛБӨР)</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>

\* "... зөрүү" гэсэн баганыг заавал шаарддаггүй. Гэхдээ анхны эсвэл тодотгосон гэдгийг зохих ёсоор ойлгомжтой тодорхойлсон төсөв ба гүйцэтгэлийн хоорондох зэрэгцүүлэлтийг тусган оруулж болох юм.

**Нэмэлт баганын арга хандлага**

**“ХХ” засгийн газрын 20XX оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жил**

**Жилийн төсөв ба санхүүгийн тайлангийн аль алины хувьд аккруэл суурийг мөрддөг**

**(Санхүүгийн үр дүнгийн тайлангийн хувьд зөвхөн үлгэрчлэн харуулав. Бусад санхүүгийн тайлангийн хувьд адилтгах толилуулгыг хэрэглэнэ.)**

Гүйцэтгэл 20XX-1	(Тооцооны нэгжээр)	Гүйцэтгэл 20XX	Тодотгосон төсөв 20XX	Анхны төсөв 20XX	Анхны төсөв ба гүйцэтгэлийн хоорондох зөрүү*
	<b>ОРЛОГО</b>				
X	Татвар	X	X	X	X
X	Хураамж, төлбөр, торгууль, лиценз	X	X	X	X
X	Арилжааны ажил гүйлгээний орлого	X	X	X	X
X	Бусад засгийн газраас авсан шилжүүлэг	X	X	X	X
X	Бусад орлого	X	X	X	X
<b>X</b>	<b>Нийт орлого</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>
	<b>ЗАРДАЛ</b>				
(X)	Цалин хөлс ба ажилтны тэтгэмж	(X)	(X)	(X)	(X)
(X)	Буцалтгүй тусламж ба бусад шилжүүлгийн төлбөр	(X)	(X)	(X)	(X)
(X)	Ашигласан хангамжийн материал ба хэрэглээний зүйлс	(X)	(X)	(X)	(X)
(X)	Элэгдэл, хорогдуулгын зардал	(X)	(X)	(X)	(X)
(X)	Бусад зардал	(X)	(X)	(X)	(X)
(X)	Санхүүгийн зардал	(X)	(X)	(X)	(X)
<b>(X)</b>	<b>Нийт зардал</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>
X	Хараат байгууллагын ашгийн хувь хэсэг	X	X	X	X

САНХҮҮГИЙН ТАЙЛАН ДАХЬ ТӨСВИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОЛИЛУУЛГА

<b>X</b>	<b>Тайлант үеийн ашиг/(алдагдал)</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>
X	Үүнээс: Хяналт тавигч байгууллагын эздэд хамаарах	X	X	X	X
X	Хяналтын бус хувь оролцоонд хамаарах	X	X	X	X
<b>X</b>		<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>

\* "... зөрүү" гэсэн баганыг заавал шаарддаггүй. Гэхдээ анхны эсвэл тодотгосон гэдгийг зохих ёсоор ойлгомжтой тодорхойлсон төсөв ба гүйцэтгэлийн хоорондох зэрэгцүүлэлтийг тусган оруулж болох юм.

## **“Х” засгийн газрын тэмдэглэл тодруулгын хэсгээс**

*(“Х” засгийн газар нь өөрийн батлагдсан төсвийг мөнгөн сууриар, санхүүгийн тайланг аккруэл сууриар толилуулдаг.)*

1. Төсвийг чиг үүргийн ангиллын дагуу мөнгөн сууриар баталдаг. Уг батлагдсан төсөв нь 20XX оны 01 дүгээр сарын 01-нээс 20XX оны 12 дугаар сарын 31 хүртэлх төсвийн жилийг хамардаг бөгөөд тус засгийн газрын үндсэн секторын хүрээн дэх бүх байгууллагуудыг агуулдаг. Засгийн газрын үндсэн сектор нь Тодруулга ХХ-д (УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*-гийн дагуу бэлтгэсэн) засгийн газрын хэлтэс гэж тодорхойлсон бүх байгууллагуудыг агуулдаг.
2. Анхны төсвийг ... (огноо)-ны хуулиар баталсан бөгөөд ... (огноо)-д Умард бүсэд болсон газар хөдлөлтийн улмаас ... (огноо)-ны хуулиар уг гамшгийг арилгахад дэмжлэг үзүүлэх ХХХ-ийн нэмэлт төсвийн хуваарилалтыг баталсан. Тухайн санхүүгийн тайлантай хамт гаргасан, Үйл Ажиллагааны Тойм ба Төсвийн Үр Дүнгийн тайлан илтгэлд уг анхны төсвийн зорилт, бодлогууд болон дараагийн засвар өөрчлөлтийг илүү дэлгэрэнгүй тайлбарласан.
3. Эрүүл мэндийн чиг үүргийн тодотгосон төсвөөс 15 хувиар (анхны төсвөөс 25 хувиар) давсан гүйцэтгэлийн зарлага нь газар хөдлөлтийн улмаас хуулиар баталсан түвшингээс хэтэрсэн зарлагын үр дүн юм. Баталсан тодотгосон төсөв ба гүйцэтгэлийн дүнгийн хооронд өөр материаллаг зөрүү байхгүй.
4. Төсвийн болон нягтлан бодох бүртгэлийн сууриуд нь өөр юм. Санхүүгийн үр дүнгийн тайлан дахь зардлын шинж төрөлд үндэслэсэн ангиллыг ашигласнаар нийт засгийн газрын санхүүгийн тайланг аккруэл сууриар бэлтгэдэг. 20XX оны 01 дүгээр сарын 01-нээс 20XX оны 12 дугаар сарын 31-нээрх төсвийн жилийн санхүүгийн тайлан нь хяналтанд буй бүх байгууллагуудыг, үүн дотроо улсын секторын худалдаа арилжааны байгууллагуудыг багтаасан нэгтгэсэн санхүүгийн тайлан юм. Тус санхүүгийн тайлан нь мөнгөн сууриар баталдаг төсвөөс өөр бөгөөд засгийн газрын зөвхөн үндсэн секторыг тусгадаг. Үүнд: улсын секторын худалдаа арилжааны байгууллагууд, засгийн газрын зах зээлийн бус бусад зарим байгууллагууд болон үйл ажиллагаанууд хамаардаггүй.
5. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг аккруэл сууриас мөнгөн сууриар дахин илэрхийлсэн бөгөөд уг батлагдсан тодотгосон төсөвтэй ижил суурьтай болгохын тулд чиг үүргийн ангиллаар түүнийг дахин ангилсан. Гүйцэтгэлийн дүнгүүдийг уг батлагдсан тодотгосон төсөвтэй зэрэгцүүлэгдэх сууриар илэрхийлэхийн тулд төсвийн байнгын хуваарилалттай холбоотой цаг хугацааны зөрүү, хамрагдах байгууллагуудын зөрүүний (улсын секторын худалдаа арилжааны байгууллагуудын) хувьд тухайн санхүүгийн тайлангийн дүнгүүдэд тохируулга хийсэн. Эдгээр тохируулгын дүнг дараах хүснэгтэнд тодорхойлсон.



САНХҮҮГИЙН ТАЙЛАН ДАХЬ ТӨСВИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОЛИЛУУЛГА

6. Төсөв ба Гүйцэтгэлийн Дүнгүүдийн Зэрэгцүүлэлтийн Тайлантай толилуулсантай зэрэгцүүлэгдэх сууриар илэрхийлсэн гүйцэтгэлийн дүн болон 20XX оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн Мөнгөн Гүйлгээний Тайланд тусгасан гүйцэтгэлийн дүн хоорондох тохируулгыг доорх хүснэгтэнд харуулав. Тухайн санхүүгийн тайлан болон төсвийн баримт бичгийг нэг ижил тайлант үеэр бэлтгэдэг. Дараах байгууллагын зөрүү байдаг. Үүнд: төсвийг засгийн газрын үндсэн секторын хувьд бэлтгэдэг бол санхүүгийн тайлан нь уг засгийн газрын хяналтанд буй бүх байгууллагуудыг нэгтгэдэг. Мөн суурийн зөрүү байдаг: төсвийг мөнгөн сууриар, харин санхүүгийн тайланг аккрузал сууриар бэлтгэдэг.

	Үйл ажиллагаа	Санхүүжилт	Хөрөнгө оруулалт	Нийт дүн
Төсөв ба Гүйцэтгэлийн Зэрэгцүүлэлтийн Тайланд толилуулсантай зэрэгцүүлэгдэх сууриар илэрхийлсэн гүйцэтгэлийн дүн	X	X	X	X
Суурийн зөрүү	X	X	X	X
Цаг хугацааны зөрүү	X	X	X	X
Байгууллагын зөрүү	X	X	X	X
Мөнгөн гүйлгээний тайлан дахь гүйцэтгэлийн дүн	X	X	X	X

(Энэхүү тохируулгыг Төсөв ба Гүйцэтгэлийн Дүнгүүдийн Зэрэгцүүлэлтийн Тайланд эсвэл тэмдэглэл тодруулга байдлаар тусган оруулж болно.)

**Дэмжих тэмдэглэл тодруулга: Мөнгөн сууриар илэрхийлсэн хоёр жилийн төсөв - “Б” засгийн газрын 20XX оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жил**

	Хоёр төсвийн жилийн анхны төсөв	1* дэх жилийн зорилгот төсөв	1 дэх жилийн засварласан төсөв	1* дэх жилийн зэрэгцүүлэгдэх сууриар илэрхийлсэн гүйцэтгэл	2 дахь жилд ашиглаж болох үлдэгдэл	2 дахь жилийн зорилгот төсөв	2 дахь жилийн засварласан төсөв	2 дахь жилийн зэрэгцүүлэг дэх сууриар илэрхийлсэн гүйцэтгэл	Уг төсвийн жилийн гүйцэтгэл ба төсвийн хоорондох зөрүү*
(Тооцооны нэгжээр)									
<b>ОРЛОГО</b>									
Татвар	X	X	X	X	X	X	X	X	X
Тусламжийн гэрээ	X	X	X	X	X	X	X	X	X
Орлого:									
Зээллэг									
Орлого:									
Үндсэн хөрөнгийн данснаас хасалт									
Худалдааны үйл ажиллагаа	X	X	X	X	X	X	X	X	X
Бусад орлого	X	X	X	X	X	X	X	X	X
<b>Нийт орлого</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>	<b>X</b>
<b>ТӨЛБӨР</b>									
Эрүүл мэнд	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Боловсрол	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Нийгмийн хэв журам ба аюулгүй	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)

САНХҮҮГИЙН ТАЙЛАН ДАХЬ ТӨСВИЙН МЭДЭЭЛЛИЙН ТОЛИЛУУЛГА

байдал	(X)										(X)
Нийгмийн хамгаалал	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Батлан хамгаалах Орон сууц, нийтийн аж ахуй	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Амралт, соёл, шашин	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Эдийн засгийн асуудлууд	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
Бусад	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)	(X)
<b>Нийт төлбөр</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>
<b>ЦЭВЭР ОРЛОГО (ТӨЛБӨР)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>	<b>(X)</b>

\* Энэ баганыг заавал шаарддаггүй. Гэхдээ анхны эсвэл тодотгосон гэдгийг зохих ёсоор ойлгомжтой тодорхойлсон төсөв ба гүйцэтгэлийн хоорондох зэрэгцүүлэлтийг тусган оруулж болох юм.

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) 25, *Ажилтны Тэтгэмж*-ийг УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ээр орлуулсан. Энэ Стандартыг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Үүний үр дүнд УСНББОУС 25-ыг цаашид мөрдөхгүй бөгөөд хүчингүй болгосон.

## УСНББОУС 26–МӨНГӨ БИЙ БОЛГОГЧ ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) 36, *Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-аас үндсэндээ бэлтгэсэн болно. НББОУС 1-ээс авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон EC4M 6XH, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)

Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.

## **УСНББОУС 26-МӨНГӨ БИЙ БОЛГОГЧ ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ**

### **УСНББОУС-ын түүх**

*Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.*

УСНББОУС 26, Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт-ыг 2008 оны 2 дугаар сард гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 26-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл* (2017 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж* (2016 оны 7 дугаар сард гаргасан)
- *Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт* (УСНББОУС 21, *Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*, УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт-ын нэмэлт өөрчлөлтүүд*) (2016 оны 7 дугаар сард гаргасан)
- *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал* (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- *УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд* (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 37, *Хамтын Хэлэлцээр* (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан* (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 33, *Аккрузал Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх* (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- *УСНББОУС 2011-ийн Сайжруулалтууд* (2011 оны 10 дугаар сард гаргасан)
- *УСНББОУС-ын Сайжруулалтууд* (2010 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 27, *Хөдөө Аж Ахуй* (2009 оны 12 дугаар сард гаргасан)
- УСНББОУС 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба Хэмжилт* (2010 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 31, *Биет Бус Хөрөнгө* (2010 оны 01 дүгээр сард гаргасан)
- *УСНББОУС-ын Сайжруулалтууд* (2010 оны 11 дүгээр сард гаргасан)

**УСНББОУС 26-гийн нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт**

<b>Өөрчлөгдсөн параграф</b>	<b>Хэрхэн өөрчилсөн</b>	<b>Юугаар өөрчилсөн</b>
Танилцуулга хэсэг	Хассан	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
2	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 27, 2009 оны 12-р сар УСНББОУС 29, 2010 оны 01-р сар УСНББОУС 31, 2010 оны 01-р сар УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт, 2016 оны 7-р сар УСНББОУС 39, 2016 оны 7-р сар УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
3	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
4	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
5	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
6	Хассан	Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт, 2016 оны 7-р сар
7	Хассан	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
8	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 27, 2009 оны 12-р сар УСНББОУС 29, 2010 оны 01-р сар УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
9	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 29, 2010 оны 01-р сар
11	Хассан	Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт, 2016 оны 7-р сар
12	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
18	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
18А	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
20А	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
23	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
27	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 11-р сар
33	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
71	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
73	Нэмэлт өөрчлөлт	Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт, 2016 оны 7-р сар

МӨНГӨ БИЙ БОЛГОГЧ ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

73А	Шинэ	Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт, 2016 оны 7-р сар
76	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
88	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
90А	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
90Б	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
90В	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
90Г	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
90Д	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
90Е	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
90Ж	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
90И	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
90К	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
90Л	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
90М	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
90Н	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
90О	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
90П	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
90Р	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
91	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
92	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
96	Хассан	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
97А	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
97Б	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
97В	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
97Г	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
97Д	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
97Е	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
97Ж	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
97И	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
98	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
99	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
100	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
102	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
103	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
106	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар



МӨНГӨ БИЙ БОЛГОГЧ ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

107	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
108	Нэмэлт өөрчлөлт	Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт, 2016 оны 7-р сар УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
108А	Шинэ	Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт, 2016 оны 7-р сар
110	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
111	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
111А	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
111Б	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
115	Нэмэлт өөрчлөлт	Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт, 2016 оны 7-р сар
120	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
122	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
122А	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
123	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
124	Нэмэлт өөрчлөлт	Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт, 2016 оны 7-р сар УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
125	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
126А	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар
126Б	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2010 оны 01-р сар
126В	Шинэ	УСНББОУС 31, 2010 оны 01-р сар
126Г	Шинэ	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
126Д	Шинэ	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
126Е	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 04-р сар
126Ж	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
126И	Шинэ	Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт, 2016 оны 7-р сар
126К	Шинэ	УСНББОУС 39, 2016 оны 7-р сар
126Л	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
127	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар

2008 оны 02 дугаар сар

**УСНББОУС 26–МӨНГӨ БИЙ БОЛГОГЧ ХӨРӨНГИЙН ҮНЭ  
ЦЭНИЙН БУУРАЛТ**

**АГУУЛГА**

	Параграф
Зорилго	1
Цар хүрээ	2-12
Тодорхойлолт	13-20
Мөнгө бий болгогч хөрөнгө	14-18
Элэгдэл	19
Үнэ цэнийн бууралт	20
Үнэ цэнэ буурсан байж болох хөрөнгийг тодорхойлох	20А-30
Нөхөгдөх дүнг хэмжих	31-70
Тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн нөхөгдөх дүнг хэмжих	37
Борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ	38-42
Ашиглалтын үнэ цэнэ	43-70
Ирээдүйн мөнгөн гүйлгээний тооцооллын үндэслэл	46-51
Ирээдүйн мөнгөн гүйлгээний тооцооллын бүрэлдэхүүн	52-66
Гадаад валютаарх ирээдүйн мөнгөн гүйлгээ	67
Дискаунтын хувь	68-70
Үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөх ба хэмжих	71-75
Мөнгө бий болгогч нэгжүүд ба гүүдвил	76-97
Хөрөнгийн харъяалагдах мөнгө бий болгогч нэгжийг тогтоох	77-84
Мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүн ба дансны үнэ	85-90
Мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтын гарз	91-97
Гүүдвил ба хяналтын бус хувь оролцоо бүхий мөнгө бий болгогч нэгжүүдийн үнэ цэнийн бууралтын сорил	97А-97И
Үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах	98-111
Бие даасан хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах	106-109
Мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах	110-111
Гүүдвиллийн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах	111А-111Б
Хөрөнгийн дахин ангилал	112-113
Тодруулга	114-125
Тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийг агуулсан мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүнг хэмжихэд ашигласан тооцооллын тодруулга	123-125
Хүчин төгөлдөр болох хугацаа	126-127
Хавсралт А: Мөрдөх заавар удирдамж	
Хавсралт Б: Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт	
Дүгнэлтийн үндэслэл	
Үлгэрчилсэн шийдвэрийн мод	
Хэрэгжүүлэх заавар удирдамж	
НББОУС 36-тай харьцуулалт	

## МӨНГӨ БИЙ БОЛГОГЧ ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-ыг 1-127-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 26-г түүний зорилгын агуулга, Дүгнэлтийн Үндэслэл, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

1. Энэхүү Стандартын зорилго нь мөнгө бий болгогч хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэхийг тогтоох ба уг үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрсөн гэдгийг магадлахын тулд тухайн байгууллагын мөрдөх горимуудыг тодорхойлоход оршино. Мөн энэ Стандарт нь үнэ цэнийн бууралтын гарзыг байгууллага хэзээ буцаах хэрэгтэй гэдгийг тусгайлан заах ба хийх тодруулгыг тодорхойлно.

## Цар хүрээ

2. Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь доор дурдсанаас бусад, мөнгө бий болгогч хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тайлагнахдаа энэ Стандартыг мөрдөнө:
  - (а) Бараа материал (УСНББОУС 2, *Бараа Материал*-ыг үзнэ үү);
  - (б) Барилгын гэрээнээс үүссэн хөрөнгө (УСНББОУС 11, *Барилгын Гэрээ*-г үзнэ үү);
  - (в) УСНББОУС 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*-ийн цар хүрээнд хамаарах санхүүгийн хөрөнгө;
  - (г) Бодит үнэ цэнээр нь хэмжсэн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө (УСНББОУС 16, *Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө*-ийг үзнэ үү);
  - (д) [Хассан]
  - (е) Хойшлогдсон татварын хөрөнгө (хойшлогдсон татварын хөрөнгийг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг үзнэ үү);
  - (ж) Ажилтны тэтгэмжтэй холбоотойгоор үүссэн хөрөнгө (УСНББОУС 19, *Ажилтны Тэтгэмж*-ийг үзнэ үү);
  - (и) [Хассан]
  - (к) [Хассан]
  - (л) УСНББОУС 27, *Хөдөө Аж Ахуй*-н цар хүрээнд хамаарах хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой бөгөөд борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээр хэмждэг биологийн хөрөнгө;
  - (м) Даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартын цар хүрээнд хамаарах даатгалын гэрээнд заасан даатгагчийн гэрээний эрхийн дагуу үүсэх хойшлогдсон худалдан авалтын өртөг болон биет бус хөрөнгө; ба
  - (н) [Хассан]

(о) **Үнэ цэнийн бууралтын нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг нь өөр Стандартад тусгасан мөнгө бий болгогч бусад хөрөнгө.**

3. [Хассан]
4. [Хассан]
5. 13-р параграфт тодорхойлсон, мөнгө бий болгодоггүй хөрөнгүүдийг эзэмшдэг улсын секторын байгууллагууд нь ийм хөрөнгөндөө УСНББОУС 21, *Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-ыг мөрдөнө.
6. [Хассан]
7. [Хассан]
8. Бараа материал, түүнчлэн барилгын гэрээнээс үүссэн мөнгө бий болгогч хөрөнгүүдэд мөрдөгдөх одоогийн стандартууд нь эдгээрийг хүлээн зөвшөөрөх ба хэмжих шаардлагуудыг агуулсан байдаг учраас эдгээр хөрөнгөнд энэ Стандартыг мөрдөхгүй. Хойшлогдсон татварын хөрөнгө, ажилтны тэтгэмжтэй холбоотой хөрөнгө, даатгалын гэрээнд заасан даатгагчийн гэрээний эрхээс үүссэн хойшлогдсон худалдан авалтын өртөг болон биет бус хөрөнгүүдэд энэ Стандартыг мөрдөхгүй. Ийм хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралтыг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартуудад авч үздэг. Мөн хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой бөгөөд борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээр нь хэмждэг биологийн хөрөнгийн хувьд энэ Стандартыг мөрдөхгүй. Хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой биологийн хөрөнгүүдийг авч үздэг УСНББОУС 27 нь хэмжилтийн шаардлагуудыг агуулсан байдаг.
9. УСНББОУС 28, *Санхүүгийн Хэрэглүүр: Топилуулга*-ын цар хүрээнд хамаарах аливаа санхүүгийн хөрөнгөнд энэ Стандартыг мөрдөхгүй. Эдгээр хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг УСНББОУС 29-д авч үзнэ.
10. Энэ Стандарт нь УСНББОУС 16-гийн дагуу бодит үнэ цэнээр бүртгэсэн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөнд үнэ цэнийн бууралтын сорилыг мөрдөхийг шаарддаггүй. УСНББОУС 16-гийн бодит үнэ цэнийн загварын дагуу хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг тухайн тайлангийн өдрөөр түүний бодит үнэ цэнээр бүртгэх бөгөөд аливаа үнэ цэнийн бууралтыг уг үнэлгээнд харгалзан үздэг.
11. [Хассан]
12. Дараах этгээдэд оруулсан хөрөнгө оруулалт нь УСНББОУС 29-ийн цар хүрээнд хамаарахгүй санхүүгийн хөрөнгө юм:
  - (а) УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*-д тодорхойлсон, хяналтанд буй байгууллагууд;

- (б) УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*-д тодорхойлсон хараат байгууллагууд;
- (в) УСНББОУС 37, *Хамтын Хэлэлцээр*-т тодорхойлсон хамтын хэлэлцээрүүд.

Эдгээр хөрөнгө оруулалт нь мөнгө бий болгогч хөрөнгийн шинж чанартай байх тохиолдолд тэдгээрийг энэ Стандартын дагуу тайлагнана. Эдгээр хөрөнгө оруулалт нь мөнгө бий болгодоггүй хөрөнгийн шинж чанартай байх тохиолдолд тэдгээрийг УСНББОУС 21-ийн дагуу тайлагнана.

## Тодорхойлолт

13. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

**Мөнгө бий болгогч нэгж** гэдэг нь бусад хөрөнгө буюу хөрөнгүүдийн бүлгийн мөнгөн орлогын гүйлгээнээс бүрэн хамааралгүй, тасралтгүй ашиглалтын явцад мөнгөн орлогын гүйлгээг бий болгодог бөгөөд арилжааны өгөөж бий болгох үндсэн зорилготойгоор эзэмшиж буй хөрөнгүүдийн тодорхойлж болох хамгийн бага бүлэг юм.

**Нөхөгдөх дүн** гэдэг нь хөрөнгө буюу мөнгө бий болгогч нэгжийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ ба түүний ашиглалтын үнэ цэнийн аль өндөр нь юм.

**Мөнгө бий болгогч хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ** гэдэг нь тухайн хөрөнгийн тасралтгүй ашиглалтаас болон түүний ашиглалтын хугацааны эцэст данснаас хасалтаас бий болохоор хүлээгдэж буй тооцоолсон ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ юм.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д дахин нийтэлсэн болно.

## Мөнгө бий болгогч хөрөнгө

14. Мөнгө бий болгогч хөрөнгө нь худалдаа арилжааны өгөөж бий болгох үндсэн зорилготойгоор эзэмшиж буй хөрөнгө юм. Ашгийн төлөө байгууллагын хэрэглэдэг арга маягтай нийцсэн байдлаар хөрөнгийг ашигладаг тохиолдолд уг хөрөнгө нь арилжааны үр өгөөж бий болгодог. “Арилжааны үр өгөөж” бий болгохын тулд хөрөнгийг эзэмших нь тухайн байгууллага (а) уг хөрөнгөөс (эсвэл тухайн хөрөнгө түүний нэг хэсэг нь болдог мөнгө бий болгогч нэгжээс) эерэг мөнгөн орлогын гүйлгээ үүсгэх, ба (б) хөрөнгийг эзэмшихтэй холбоотой эрсдэлийг тусгах тийм арилжааны үр өгөөж олох санаа бодолтой байгаа гэдгийг илэрхийлнэ. Хэдийгээр хөрөнгө нь арилжааны үр өгөөж бий болгох зорилтыг тухайн тайлант үеийн туршид ханган биелүүлээгүй боловч уг хөрөнгийг ийм үндсэн зорилготойгоор эзэмшдэг байж болно. Нөгөө талаас, хөрөнгө нь тухайн

тайлант үеийн туршид ашиг, алдагдалгүй хугарлын цэг дээр байх буюу арилжааны үр өгөөж үүсгэсэн боловч мөнгө бий болгодоггүй хөрөнгө байж болох юм. Өөрөөр тусгайлан зааснаас бусад тохиолдолд энэ Стандартын дараах параграфууд дахь хөрөнгө буюу хөрөнгүүд гэсэн хэллэг нь “мөнгө бий болгогч хөрөнгө (хөрөнгүүд)”-ийг илэрхийлнэ.

15. Улсын секторын байгууллагууд нь өөрийн ихэнх хөрөнгийг арилжааны үр өгөөж бий болгох зорилгоор эзэмшдэггүй боловч зарим хөрөнгийг ийм зорилгоор эзэмшиж болох олон нөхцөл байдал байдаг. Жишээлбэл; эмнэлэг нь төлбөртэй хэвтэн эмчлүүлэгчдэд зориулан барилгыг ашигладаг байж болно. Улсын секторын байгууллагын мөнгө бий болгогч хөрөнгүүд нь тухайн байгууллагын мөнгө бий болгодоггүй хөрөнгүүдээс хараат бусаар ажилладаг байж болох юм. Жишээлбэл; үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн алба нь газрын асуудал эрхэлсэн албанаас хараат бус газрын бүртгэлийн хураамжийг хүлээн авдаг байж болно.
16. Хөрөнгийг үндсэндээ үйлчилгээ үзүүлэх зорилгоор эзэмшдэг боловч зарим тохиолдолд хөрөнгө нь мөнгөн гүйлгээ үүсгэдэг байж болох юм. Жишээлбэл; хаягдал боловсруулах үйлдвэр нь төрийн өмчит эмнэлгүүдийн гаргасан эмнэлгийн хаягдлыг аюулгүй устгахын тулд үйл ажиллагаагаа явуулдаг боловч бусад хувийн эмнэлгийн багахан хэмжээний эмнэлгийн хаягдлыг мөн арилжааны сууриар боловсруулдаг. Хувийн эмнэлгүүдээс хүлээн авсан эмнэлгийн хаягдал боловсруулалт нь уг үйлдвэрийн үйл ажиллагаанд туслах шинж чанартай бөгөөд уг мөнгөн орлого бий болгож буй хөрөнгүүдийг мөнгө бий болгодоггүй хөрөнгүүдээс ялган зааглах боломжгүй байдаг.
17. Өөр зарим тохиолдолд хөрөнгө нь мөнгөн гүйлгээг бий болгодог бөгөөд мөнгө бий болгодоггүй зорилгод түүнийг бас ашигладаг байж болох юм. Жишээлбэл; улсын эмнэлэг нь арван тасагтай бөгөөд тэдгээрийн есийг нь төлбөртэй хэвтэн эмчлүүлэгчдэд зориулан арилжааны сууриар ашигладаг. Харин нэгийг нь төлбөргүй хэвтэн эмчлүүлэгчдэд зориулан ашигладаг. Төлбөртэй ба төлбөргүй тасгуудын аль алины хэвтэн эмчлүүлэгчид нь эмнэлгийн бусад төхөөрөмж хэрэгслийг (тухайлбал, мэс заслын төхөөрөмж) хамтдаа ашигладаг. Уг байгууллага нь энэ Стандартын эсвэл УСНББОУС 21-ийн заалтуудыг мөрдөх хэрэгтэй эсэхийг тодорхойлохын тулд арилжааны үр өгөөж бий болгох зорилгоор тухайн хөрөнгийг эзэмшиж буй хэмжээг харгалзан үзэх шаардлагатай. Энэ жишээнд дурдсантай адилаар, мөнгө бий болгодоггүй бүрэлдэхүүн хэсэг нь нийт үйл ажиллагааны хувьд мэдэгдэхүйц бус хэмжээтэй бол тухайн байгууллага нь УСНББОУС 21-ийг биш, харин энэ Стандартыг мөрдөнө.
18. Зарим тохиолдолд хөрөнгийг эзэмшиж буй үндсэн зорилго нь арилжааны үр өгөөж бий болгох эсэх нь тодорхой бус байж болох юм. Ийм тохиолдолд тухайн мөнгөн гүйлгээний ач холбогдлыг үнэлэх шаардлагатай байдаг. Мөнгөн гүйлгээг бий болгож буй тухайн хөрөнгө нь УСНББОУС 21-ийг биш, харин энэ Стандартыг мөрдөхөд хүргэхүйц маш мэдэгдэхүйц хэмжээтэй эсэхийг тодорхойлоход төвөгтэй байж болох юм. Аль стандартыг мөрдөх эсэхийг тодорхойлоходоо шүүн тунгаалт хийх

шаардлагатай. Мөнгө бий болгогч хөрөнгө болон мөнгө бий болгодоггүй хөрөнгийн тодорхойлолт, түүнчлэн 14-17-р параграфын холбогдох заавар удирдамжинд нийцүүлэн шүүн тунгаалт хийхийн тулд байгууллага нь шалгуурыг боловсруулдаг. Байгууллага нь ийм шүүн тунгаалт хийхдээ ашигласан шалгуураа тодруулахыг 114-р параграфтаар шаардсан байдаг. Гэвч улсын секторын байгууллагуудын ерөнхий зорилгыг харгалзан үзвэл, тэдгээр хөрөнгө нь мөнгө бий болгодоггүй хөрөнгө байх бөгөөд иймээс УСНББОУС 21-ийг мөрдөнө гэсэн урьдчилсан төсөөлөлтэй байдаг.

- 18А Үнэ цэнийн бууралтын зорилгын хувьд гүүдвилийг мөнгө бий болгогч хөрөнгө гэж үздэг. Гүүдвил нь бусад хөрөнгүүдээс бие даасан байдлаар эдийн засгийн үр өгөөжийг бий болгодоггүй бөгөөд түүний үнэ цэнийн бууралтыг бусад хөрөнгүүдийн бүлгийн нэг хэсэг байдлаар үнэлдэг. Бие даасан хөрөнгүүдийн үнэлгээг УСНББОУС 21-д авч үзнэ. Гүүдвил нь мөнгөн орлогын гүйлгээ үүсэх эсвэл нэгтгэгчийн цэвэр мөнгөн зарлагыг бууруулах үр дүнтэй байх зөвхөн тийм тохиолдолд түүнийг хүлээн зөвшөөрнө. Холбогдох мөнгөн гүйлгээг бий болгохгүй үйлчилгээний чадавхийн хувьд гүүдвилийг хүлээн зөвшөөрөхгүй. Үнэ цэнийн бууралтыг үнэлэхийн тулд УСНББОУС 21-д ашигласан нөхөгдөх үйлчилгээний дүнд үйлчилгээний чадавхи хамаарна. Иймээс байгууллага нь гүүдвилийн үнэ цэнийг бууруулах эсэхийг тодорхойлохын тулд энэ Стандартыг мөрдөнө.

### **Элэгдэл**

19. Элэгдэл ба хорогдуулга нь хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид хуваарилах системтэй хуваарилалт юм. Биет бус хөрөнгийн хувьд “элэгдэл” гэдгийн оронд “хорогдуулга” гэсэн нэр томъёог ихэвчлэн ашигладаг. Эдгээр нэр томъёо нь ижил утгатай юм.

### **Үнэ цэнийн бууралт**

20. Үнэ цэнийн бууралт нь хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн бууралтыг элэгдлээр (хорогдуулгаар) дамжуулан системтэй хүлээн зөвшөөрөх дүнгээс илүү буюу өндрөөр тухайн хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхид учрах гарз гэж УСНББОУС 21-д тодорхойлдог. Иймээс үнэ цэнийн бууралт нь тухайн хөрөнгийг хянаж буй байгууллага дахь түүний хэрэгцээт чанарын бууралтыг тусган илэрхийлдэг. Жишээлбэл; байгууллага нь хотын захиргааны авто зогсоолыг эзэмшдэг бөгөөд одоогоор түүнийг хүчин чадлын 25 хувиар ашиглаж байна. Үүнийг арилжааны зорилгоор эзэмшдэг бөгөөд удирдлага нь түүний ашиглалтыг хүчин чадлын 75 хувь буюу түүнээс дээш болгосон тохиолдолд арилжааны үр өгөөж бий болно гэж тооцоолсон. Авто зогсоолын төлбөрийг нэмсэнээр түүний ашиглалт дагалдан буурахгүй. Уг хөрөнгийн дансны үнэ нь нөхөгдөх дүнгээсээ давсан учраас түүний үнэ цэнэ буурсан гэж үзнэ.



## Үнэ цэнэ буурсан байж болох хөрөнгийг тодорхойлох

- 20А. Нөхөгдөх үйлчилгээний дүнг хэзээ тодорхойлохыг 21-30-р параграфт тусгайлан заасан. Эдгээр шаардлагуудад “хөрөнгө” гэсэн нэр томъёог ашигласан боловч энэ нэр томъёог бие даасан хөрөнгө эсвэл мөнгө бий болгогч нэгжид ижил утгаар хэрэглэнэ. Энэхүү Стандартын үлдсэн зүйл заалтуудыг дараах байдлаар бүтэцчлэн зохион байгуулсан:
- (а) Нөхөгдөх дүнг хэмжих шаардлагуудыг 31-70-р параграфт заасан. Эдгээр шаардлагуудад мөн “хөрөнгө” гэсэн нэр томъёог ашигласан боловч энэ нэр томъёог бие даасан хөрөнгө эсвэл мөнгө бий болгогч нэгжид ижил утгаар хэрэглэнэ.
  - (б) Үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөх ба хэмжих шаардлагуудыг 71-97-р параграфт заасан. Гүүдвилээс бусад бие даасан хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзын хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийг 71-75-р параграфт авч үзсэн. Мөнгө бий болгогч нэгж ба гүүдвیلیйн үнэ цэнийн бууралтын гарзын хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийг 76-97-р параграфт заасан.
  - (в) Хөрөнгө эсвэл мөнгө бий болгогч нэгжийн хувьд өмнөх тайлант үеүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах шаардлагуудыг 98-105-р параграфт заасан. Дахин дурдахад, эдгээр шаардлагуудад “хөрөнгө” гэсэн нэр томъёог ашигласан боловч энэ нэр томъёог бие даасан хөрөнгө эсвэл мөнгө бий болгогч нэгжид ижил утгаар хэрэглэнэ. Бие даасан хөрөнгөнд хамаарах нэмэлт шаардлагуудыг 106-109-р параграфт, мөнгө бий болгогч нэгжид хамаарах нэмэлт шаардлагуудыг 110-111-р параграфт, гүүдвйлд хамаарах нэмэлт шаардлагуудыг 111А-111Б параграфт тус тус заасан.
  - (г) Хөрөнгийг мөнгө бий болгогч хөрөнгөөс мөнгө бий болгодоггүй хөрөнгө болгох эсвэл мөнгө бий болгодоггүй хөрөнгөөс мөнгө бий болгогч хөрөнгө болгох дахин ангиллын шаардлагуудыг 112-113-р параграфт заасан.
  - (д) Хөрөнгө ба мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтын гарз болон үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтын талаархи тодруулга хийх мэдээллийг 114-122А параграфт тусгайлан заасан. Үнэ цэнийн бууралтыг нь сорьж шалгах зорилгоор тэдгээрт гүүдвیلیйг эсвэл тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийг хуваарилдаг тийм мөнгө бий болгогч нэгжүүдийн талаархи тодруулгын нэмэлт шаардлагуудыг 123-125-р параграфт заасан.
21. Хөрөнгийн дансны үнэ нь түүний нөхөгдөх дүнгээс хэтэрсэн үед хөрөнгийн үнэ цэнэ буурдаг. Үнэ цэнийн бууралтын гарз үүссэн байж болох зарим шинж тэмдгийг 25-27-р параграфт тодорхойлсон. Хэрэв эдгээр шинж тэмдгийн аль нэг нь илэрвэл байгууллага нь нөхөгдөх дүнгийн албан ёсны тооцоолол хийх шаардлагатай байдаг. 23-р параграфт зааснаас бусад тохиолдолд хэрэв үнэ цэнэ бууралтын гарзын ямар нэг шинж тэмдэг

илрээгүй бол байгууллага нь нөхөгдөх дүнгийн албан ёсны тооцоолол хийхийг энэ Стандартаар шаардахгүй.

22. **Байгууллага нь хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болох ямар нэг шинж тэмдэг байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст үнэлнэ. Хэрэв ийм ямар нэг шинж тэмдэг илэрвэл байгууллага нь хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцоолно.**
23. **Үнэ цэнийн бууралтын ямар нэг шинж тэмдэг байгаа эсэхээс үл хамааран байгууллага нь мөн дараах зүйлсийг гүйцэтгэнэ:**
- (а) **Тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгө эсвэл ашиглахад хараахан бэлэн болоогүй биет бус хөрөнгийн дансны үнийг түүний нөхөгдөх дүнтэй зэрэгцүүлснээр үнэ цэнийн бууралтыг жил бүр сорьж шалгах. Хэрэв энэхүү үнэ цэнийн бууралтын сорилыг жил бүрийн нэг ижил хугацаанд хийдэг бол жилийн турш дахь дурын хугацаанд үүнийг гүйцэтгэж болно. Харин өөр өөр биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг өөр өөр хугацаанд сорьж шалгаж болно. Гэхдээ ийм биет бус хөрөнгийг тайлант жилийн дундуур анх хүлээн зөвшөөрсөн бол тэрхүү биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тухайн тайлант жилийн эцэс болохоос өмнө сорьж шалгана.**
  - (б) **Улсын секторын нэгдлээр олж эзэмшсэн гүүдвилийн үнэ цэнийн бууралтыг 90А-90Р параграфын дагуу жил бүр сорьж шалгах.**
24. **Өөрийн дансны үнийг нөхөхүйц ирээдүйн хангалттай эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг бий болгох уг биет бус хөрөнгийн чадвар боломж нь ашиглахад бэлэн болсны дараах үетэй харьцуулахад ашиглахад хараахан бэлэн болоогүй байх үедээ ихэвчлэн маш тодорхой бус байдаг. Иймээс энэ Стандарт нь ашиглахад хараахан бэлэн болоогүй байгаа биет бус хөрөнгийн дансны үнийн хувьд үнэ цэнийн бууралтыг наад зах нь жил бүр сорьж шалгаж байхыг байгууллагаас шаарддаг.**
25. **Хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болох ямар нэг шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлэхдээ, байгууллага хамгийн наад зах нь дараах шинж тэмдгийг харгалзан үзнэ:**

**Мэдээллийн гадаад эх сурвалж**

- (а) **Хөрөнгийн зах зээлийн үнэ цэнэ нь түүний хэвийн ашиглалтаар эсвэл цаг хугацаа өнгөрснөөр буурна гэж хүлээгдэж байснаас мэдэгдэхүйц их дүнгээр тухайн тайлант үеийн туршид буурсан;**
- (б) **Тухайн байгууллагад сөрөг нөлөөтэй мэдэгдэхүйц өөрчлөлтүүд нь тэрхүү байгууллагын үйл ажиллагаа явуулдаг технологийн, зах зээлийн, эдийн засгийн болон хуулийн орчинд, эсвэл уг хөрөнгийг зориулан зарцуулах зах зээлд энэхүү тайлант үеийн**

туршид гарч тохиолдсон эсвэл ойрын ирээдүйд гарч тохиолдохоор байх;

- (в) Зах зээлийн хүүний түвшин эсвэл хөрөнгө оруулалтын өгөөжийн зах зээлийн бусад хувь хэмжээ нь тухайн тайлант үеийн туршид өссөн бөгөөд ийм өсөлт нь хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг тооцоолоход ашиглах дискаунтын хувь хэмжээнд нөлөөлөх ба уг хөрөнгийн нөхөгдөх дүнг материаллагаар бууруулах магадлалтай байх;

**Мэдээллийн дотоод эх сурвалж**

- (г) Хөрөнгийн хуучралт буюу биет эвдрэл, гэмтлийн талаархи нотолгоо байх;
- (д) Тухайн байгууллагад сөрөг нөлөөтэй мэдэгдэхүйц өөрчлөлтүүд нь түүний хөрөнгөө ашиглаж байгаа эсвэл ашиглахаар хүлээгдэж буй хэмжээ, арга маягт энэхүү тайлант үеийн туршид гарч тохиолдсон эсвэл ойрын ирээдүйд гарахаар хүлээгдэж байх. Хөрөнгийн ашиглалтгүй сул зогсолт, тухайн хөрөнгөнд хамааралтай үйл ажиллагааг зогсоох буюу бүтцийн өөрчлөлт хийх төлөвлөгөө, анхны хүлээгдэж байсан өдрөөс өмнө хөрөнгийг данснаас хасах төлөвлөгөө, хөрөнгийн ашиглагдах хугацаа тодорхойгүй байсныг тодорхой хязгаарлагдмал болгосон дахин үнэлэлт зэрэг нь ийм өөрчлөлтөнд хамаарна.
- (е) Хөрөнгийг барьж байгуулах ажил дуусахаас эсвэл ашиглахад бэлэн болгохоос өмнө уг барилгын ажлыг зогсоох шийдвэр.
- (ж) Хөрөнгийн эдийн засгийн гүйцэтгэл, үр дүн нь хүлээгдэж байснаас муу байх эсвэл муу болно гэдгийг илтгэсэн нотолгоо дотоод тайлагналаас бий болсон байх.

26. 25-р параграф дахь жагсаалтанд бүгдийг багтаан тусгаагүй болно. Байгууллага нь хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болохыг илтгэх бусад шинж тэмдгүүдийг тогтоож болох бөгөөд тэдгээр нь мөн хөрөнгийн нөхөгдөх дүнг тодорхойлохыг уг байгууллагаас шаардах юм.

27. Хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болохыг илтгэн харуулах дотоод тайлагналын нотолгоонд дараах зүйлсийн оршин байдал хамаарна:

- (а) Хөрөнгийг худалдан авахад зарцуулах мөнгөн гүйлгээ эсвэл тухайн хөрөнгийг ажиллуулах буюу хэвийн ажиллагааг хангах цаашдын мөнгөний хэрэгцээ нь анх төсөвлөсөн дүнгээс мэдэгдэхүйц их байх;
- (б) Хөрөнгөөс олж буй гүйцэтгэлээрх цэвэр мөнгөн гүйлгээ буюу үйл ажиллагааны ашиг, алдагдал нь төсөвлөсөн дүнгээс мэдэгдэхүйц дордсон байх;
- (в) Хөрөнгөөс олох төсөвлөсөн цэвэр мөнгөн орлого буюу ашиг мэдэгдэхүйц буурах эсвэл төсөвлөсөн алдагдал мэдэгдэхүйц нэмэгдэх; эсвэл

- (г) Тухайн тайлант үеийн дүнг ирээдүйн төсөвлөсөн дүнтэй нэгтгэн авч үзэхэд уг хөрөнгийн хувьд алдагдалтай эсвэл цэвэр мөнгөн зарлагын гүйлгээтэй байх.
28. 23-р параграфт дурдсанчлан, энэ Стандарт нь тодорхой бус ашиглалтын хугацаатай эсвэл ашиглахад хараахан бэлэн болоогүй биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг наад зах нь жил бүр сорьж шалгахыг шаарддаг. 23-р параграфт заасан шаардлагуудыг мөрдөхөөс гадна хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцоолох шаардлагатай эсэхийг тогтоохдоо материаллаг байдлын зарчмыг мөрдөнө. Жишээлбэл; хөрөнгийн нөхөгдөх дүн нь түүний дансны үнээс мэдэгдэхүйц их гэдгийг өмнөх тооцоолол харуулж байгаа бөгөөд энэхүү зөрүүг арилгах ямар нэг үйл явдал гарч тохиолдоогүй бол тухайн байгууллага нь уг хөрөнгийн нөхөгдөх дүнг дахин тооцоолох шаардлагагүй. Үүнтэй адилаар, хөрөнгийн нөхөгдөх дүн нь 25-р параграфт жагсаан харуулсан аль нэг (эсвэл хэд хэдэн) шинж тэмдэгт хамаарахгүй гэдгийг өмнөх шинжилгээгээр харуулж болох юм.
29. Зах зээлийн хүүний түвшин эсвэл хөрөнгө оруулалтын өгөөжийн зах зээлийн бусад хувь хэмжээ нь тухайн тайлант үеийн туршид өссөн боловч байгууллага нь дараах тохиолдолд 28-р параграфт жишээ болгон дурдсантай адилаар, хөрөнгийн нөхөгдөх дүнгийн албан ёсны тооцоолол хийх шаардлагагүй юм:
- (а) Эдгээр зах зээлийн хүүний түвшний өсөлт нь хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг тооцоолоход ашигласан дискаунтын хувь хэмжээнд нөлөөлөх магадлал бага байх. Жишээлбэл; богино хугацаат хүүний түвшний өсөлт нь урт хугацаат үлдэх ашиглалтын хугацаатай хөрөнгийн хувьд ашигласан дискаунтын түвшинд материаллаг нөлөө үзүүлэхгүй байж болох юм.
- (б) Эдгээр зах зээлийн хүүний түвшний өсөлт нь хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг тооцоолоход ашигласан дискаунтын хувь хэмжээнд нөлөөлөх магадлалтай боловч нөхөгдөх дүнгийн талаархи өмнөх мэдрэмжийн шинжилгээ нь доорх зүйлсийг харуулж байх:
- (i) Ирээдүйн мөнгөн гүйлгээ нь мөн өсөх магадлалтай учраас нөхөгдөх дүнд материаллаг бууралт гарах магадлал багатай. (Жишээлбэл; зарим тохиолдолд байгууллага нь зах зээлийн хүүний түвшний аливаа өсөлтийг нөхөхийн тулд өөрийн орлогыг (ихэвчлэн арилжааны орлогыг) тохируулна гэдгээ харуулах чадвартай байж болох юм); эсвэл
- (ii) Нөхөгдөх дүнгийн бууралт нь үнэ цэнийн бууралтын материаллаг гарз бий болгох магадлал багатай.
30. Хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болох шинж тэмдэг байгаа бол хэдийгээр тухайн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөөгүй боловч энэ нь хөрөнгийн ашиглалтын үлдсэн хугацаа, элэгдлийн (хорогдуулгын) арга, хөрөнгийн үлдэх өртгийг дахин хянан үзэж, уг хөрөнгөнд хамаарах Стандартын дагуу тохируулах шаардлагатай гэдгийг илэрхийлж болох юм.

## Нөхөгдөх дүнг хэмжих

31. Энэ Стандарт нь хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ ба түүний ашиглалтын үнэ цэнийн аль өндрөөр нөхөгдөх дүнг тодорхойлдог. Нөхөгдөх дүнг хэмжихэд хамаарах шаардлагуудыг 32-70-р параграфт заасан. Эдгээр шаардлагуудад “хөрөнгө” гэсэн нэр томъёог ашигласан боловч энэ нэр томъёог бие даасан хөрөнгө эсвэл мөнгө бий болгогч нэгжид ижил утгаар хэрэглэнэ.
32. Хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ ба түүний ашиглалтын үнэ цэнийн аль алиныг байнга тодорхойлох шаардлагагүй байдаг. Хэрэв эдгээр дүнгүүдийн аль нэг нь тухайн хөрөнгийн дансны үнээс илүү байвал хөрөнгийн үнэ цэнэ буураагүй бөгөөд нөгөө дүнг тооцоолох шаардлагагүй юм.
33. Хөрөнгийг идэвхитэй зах зээлд арилждаггүй байлаа ч гэсэн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийг тооцоолох боломжтой байж болно. Гэвч зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хоорондох харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгийг борлуулснаар олж болох дүнгийн талаар найдвартай<sup>1</sup> тооцоолол хийх суурь үндэслэл байхгүйн улмаас борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийг зарим үед тодорхойлох боломжгүй байдаг. Энэ тохиолдолд байгууллага нь хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг түүний нөхөгдөх дүн байдлаар ашиглаж болох юм.
34. Хэрэв хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ нь хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээс материаллагаар илүү гэж үзэх шалтгаан үндэслэл байхгүй бол тухайн хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийг түүний нөхөгдөх дүн байдлаар ашиглаж болно. Данснаас хасах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийн хувьд ийм тохиолдол байнга гардаг. Яагаад гэвэл, хөрөнгийг данснаас хасах хүртэлх түүний тасралтгүй ашиглалтаас бий болох ирээдүйн мөнгөн гүйлгээ нь өчүүхэн бага байх магадлалтай тул данснаас хасах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ нь үндсэндээ данснаас хасалтын цэвэр орлогоос бүрддэг.
35. Бие даасан хөрөнгө нь бусад хөрөнгө буюу хөрөнгүүдийн бүлгийн мөнгөн орлогоос бүрэн хамааралгүй байдлаар мөнгөн орлогыг бий болгож чадахгүй байхаас бусад тохиолдолд бие даасан хөрөнгийн хувьд нөхөгдөх дүнг тодорхойлно. Хэрэв ингэж мөнгөн орлогыг бий болгож чадахгүй бол доор дурдсанаас бусад тохиолдолд тухайн хөрөнгийн харъяалагдах мөнгө бий болгогч нэгжийн хувьд нөхөгдөх дүнг тодорхойлно (85-90-р параграфыг үзнэ үү):

---

<sup>1</sup> Найдвартай мэдээлэл нь материаллаг алдаа ба туйлшралаас ангид байх бөгөөд өөрийн илэрхийлэхээр зориулагдсан буюу илэрхийлнэ гэж үл үндэслэлтэйгээр хүлээж болох зүйлсийг үнэн зөв илэрхийлэхдээ хэрэглэгчдээс хамаардаг байж болох юм. Найдвартай байдлын тайлбарын талаархи шилжилтийн арга хандлагыг УСНББОУС 1-ийн ДҮ16-р параграфт авч хэлэлцсэн.

- (а) Хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ нь түүний дансны үнээс их байх; эсвэл
  - (б) Хөрөнгө нь мөнгө бий болгогч нэгжийн нэг хэсэг боловч бие даасан байдлаар мөнгөн гүйлгээг бий болгох чадвартай бөгөөд энэ тохиолдолд хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг түүний борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэтэй ойролцоо байдлаар тооцоолох ба борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийг тодорхойлж чадахаар байх.
36. Зарим тохиолдолд тооцоолол, дундаж дүн, хялбарчилсан тооцоолол нь борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ эсвэл ашиглалтын үнэ цэнийг тодорхойлох дэлгэрэнгүй тооцооллын боломжит ойролцоо дүнг илэрхийлж болох юм.

**Тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн нөхөгдөх дүнг хэмжих**

37. 23-р параграф нь үнэ цэнэ буурсан байж болох ямар нэг шинж тэмдэг байгаа эсэхээс үл хамааран тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн дансны үнийг түүний нөхөгдөх дүнтэй зэрэгцүүлснээр үнэ цэнийн бууралтыг жил бүр сорьж шалгахыг шаарддаг. Гэвч дараах бүх шалгуур хангагдаж байвал өмнөх тайлант үед хийсэн, ийм хөрөнгийн нөхөгдөх дүнгийн талаархи хамгийн сүүлийн дэлгэрэнгүй тооцооллыг тухайн тайлант үед уг хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сорилд хэрэглэж болно:
- (а) Биет бус хөрөнгө нь бусад хөрөнгө буюу хөрөнгүүдийн бүлгийн мөнгөн орлогоос бүрэн хамааралгүй байдлаар өөрийн тасралтгүй ашиглалтаас мөнгөн орлогыг бий болгож чадахгүй, иймээс түүний харъяалагдах мөнгө бий болгогч нэгжийн нэг хэсэг байдлаар уг биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг сорьж шалгадаг бөгөөд тухайн мөнгө бий болгогч нэгжийг бүрдүүлж буй хөрөнгө, өр төлбөр нь нөхөгдөх дүнгийн хамгийн сүүлийн тооцооллоос хойш мэдэгдэхүйц өөрчлөгдөөгүй;
  - (б) Нөхөгдөх дүнгийн хамгийн сүүлийн тооцоолол нь тухайн хөрөнгийн дансны үнээс мэдэгдэхүйц өндөр дүнг харуулсан; ба
  - (в) Нөхөгдөх дүнгийн хамгийн сүүлийн тооцооллоос хойш гарч тохиолдсон үйл явдлууд болон өөрчлөгдсөн нөхцөл байдлын шинжилгээнд үндэслэн авч үзэхэд одоогийн нөхөгдөх дүн нь тухайн хөрөнгийн дансны үнээс бага болох магадлал маш бага байх.

**Борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ**

38. Хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо нь уг хөрөнгийн данснаас хасалтанд шууд хамааруулж болох өсөн нэмэгдэх зардлын хувьд тохируулга хийсэн, харилцан хамааралгүй талуудын хоорондох ажил гүйлгээний заавал биелүүлэх борлуулалтын гэрээний үнэ юм.

39. Заавал биелүүлэх борлуулалтын гэрээ байхгүй боловч хөрөнгийг идэвхитэй зах зээлд арилждаг бол борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ нь тухайн хөрөнгийн зах зээлийн үнээс түүний данснаас хасалтын зардлыг хассан дүн байна. Зохих зах зээлийн үнэ нь ихэвчлэн одоогийн өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын үнэ байдаг. Одоогийн өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын үнэ нь бэлэн боломжтой байхгүй тохиолдолд уг ажил гүйлгээний өдөр ба тэрхүү тооцооллыг хийсэн өдрийн хоорондох хугацаанд эдийн засгийн нөхцөл байдалд мэдэгдэхүйц өөрчлөлт ороогүй бол хамгийн сүүлийн ажил гүйлгээний үнэ нь борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийг тооцоолох суурь үндэслэлээр хангаж болох юм.
40. Заавал биелүүлэх борлуулалтын гэрээ эсвэл хөрөнгийн идэвхитэй зах зээл байхгүй бол борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ нь бэлэн байгаа хамгийн сайн мэдээлэлд үндэслэдэг. Энэ мэдээлэл нь зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хоорондох харилцан хамааралгүй ажил гүйлгээгээр хөрөнгийг данснаас хассанаар уг тайлангийн өдөр тухайн байгууллагын олж авч чадах дүнгээс данснаас хасалтын зардлыг хассан дүнг тусгах бэлэн боломжтой байгаа хамгийн сайн мэдээлэлд үндэслэдэг. Энэхүү дүнг тодорхойлохдоо байгууллага нь тухайн салбар дахь ижил төсөөтэй хөрөнгүүдийн хамгийн сүүлийн үеийн ажил гүйлгээний үр дүнгүүдийг харгалзан үзэж болох юм. Борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ нь албадан борлуулалтыг тусган илэрхийлдэггүй.
41. Борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийг хэмжихдээ, өр төлбөр гэж хүлээн зөвшөөрснөөс бусад, данснаас хасалтын өртөг зардлыг хасаж тооцно. Ийм өртөг зардлын жишээнд хуулийн үйлчилгээний зардал, тэмдэгтийн хураамж болон түүнтэй адилтгах ажил гүйлгээний татвар, хөрөнгийг нүүлгэн шилжүүлэх зардал, хөрөнгийг түүний борлуулах нөхцөл байдалд оруулахтай холбоотойгоор гарсан өсөн нэмэгдэх шууд зардал хамаарна. Харин ажлаас халагдалтын тэтгэмж болон хөрөнгийн данснаас хасалтын дараа бизнесийг хумих буюу бүтцийн өөрчлөлттэй холбоотой өртөг зардал нь тухайн хөрөнгийн данснаас хасалтын өсөн нэмэгдэх шууд зардал биш юм.
42. Зарим тохиолдолд хөрөнгийн данснаас хасалт нь өр төлбөрийг тухайн худалдан авагч хариуцахыг шаарддаг бөгөөд хөрөнгө, өр төлбөрийн аль алины хувьд борлуулах зардлыг хассан зөвхөн ганц бодит үнэ цэнэтэй байдаг. Ийм тохиолдлыг хэрхэн авч үзэх талаар 89-р параграфт тайлбарласан.

### **Ашиглалтын үнэ цэнэ**

43. **Дараах элементүүдийг хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийн тооцоололд тусгана:**
- (a) **Байгууллага нь тухайн хөрөнгөөс олохоор хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн гүйлгээний тооцоолол;**

- (б) Тэдгээр ирээдүйн мөнгөн гүйлгээний дүн буюу хугацаанд гарах боломжит хэлбэлзэл өөрчлөлтүүдийн талаархи хүлээлт;
  - (в) Эрсдэлгүй хүүний одоогийн зах зээлийн хувь хэмжээгээр илэрхийлэгдэх мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ;
  - (г) Тухайн хөрөнгийн угийн тодорхойгүй байдалд хамаарах үнэ;
  - (д) Зах зээлд оролцогчид нь уг хөрөнгөөс тухайн байгууллагын олохоор хүлээж буй ирээдүйн мөнгөн гүйлгээг үнэлэн тооцохдоо харгалзан тусгах төлбөрийн чадваргүй байдал гэх мэт бусад хүчин зүйлс.
44. Хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийн тооцоолол нь дараах алхамуудаас бүрддэг:
- (а) Тухайн хөрөнгийн тасралтгүй ашиглалт болон түүний эцсийн данснаас хасалтаас бий болох ирээдүйн мөнгөн орлого ба мөнгөн зарлагын гүйлгээг тооцоолох; ба
  - (б) Тэдгээр ирээдүйн мөнгөн гүйлгээг зохих дискаунтын хувиар үржүүлэх.
45. 43(б), (г), (д) параграфт тодорхойлсон элементүүдийг уг ирээдүйн мөнгөн гүйлгээний тохируулга эсвэл дискаунтын хувийн тохируулга байдлаар тусгаж болно. Байгууллага нь ирээдүйн мөнгөн гүйлгээний дүн буюу хугацаанд гарах боломжит хэлбэлзэл өөрчлөлтүүдийн талаархи өөрийн хүлээлтийг тусгахын тулд аль ч аргыг хэрэглэсэн байлаа гэхэд уг үр дүн нь ирээдүйн мөнгөн гүйлгээний хүлээгдэж буй өнөөгийн үнэ цэнийг, өөрөөр хэлбэл боломжит бүх үр дагаврын жинэлсэн дундажийг илэрхийлэх юм. Мөрдөх заавар удирдамж нь хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг хэмжихэд өнөөгийн үнэ цэнийн арга зүйг ашиглах талаархи нэмэлт заавар удирдамжаар хангадаг.

#### ***Ирээдүйн мөнгөн гүйлгээний тооцооллын үндэслэл***

46. **Ашиглалтын үнэ цэнийг хэмжихдээ байгууллага нь:**
- (а) Тухайн хөрөнгийн үлдсэн ашиглалтын хугацааны туршид оршин байх эдийн засгийн янз бүрийн нөхцөл байдлын талаархи удирдлагын хамгийн сайн тооцооллыг илэрхийлэх үл үндэслэлтэй бөгөөд дэмжигдэхүйц таамаглалуудад үндэслэн мөнгөн гүйлгээний төсөвлөлтийг бэлтгэнэ. Гадны нотолгоонд илүү ач холбогдол өгнө;
  - (б) Удирдлагын баталсан хамгийн сүүлийн үеийн санхүүгийн төсөв/прогнозод үндэслэн мөнгөн гүйлгээний төсөвлөлтийг бэлтгэх боловч ирээдүйн бүтцийн өөрчлөлт эсвэл хөрөнгийн гүйцэтгэлийг нэмэгдүүлэх буюу сайжруулснаар бий болохоор хүлээгдэж буй аливаа тооцоолсон ирээдүйн мөнгөн орлого, мөнгөн зарлагыг харгалзан үзэхгүй. Энэхүү төсөв/прогнозод үндэслэсэн төсөвлөлт нь илүү урт хугацаа тохиромжтой



гэдгийг баталж чадахаас бусад тохиолдолд хамгийн ихдээ таван жилийн хугацааг хамарна;

- (в) **Өсөх хувь хэмжээ зохистой гэдгийг баталж чадахаас бусад тохиолдолд тогтмол эсвэл буурах өсөлтийн хувь хэмжээг дараагийн жилүүдэд ашигласнаар төсөв/прогнозод үндэслэсэн энэхүү төсөвлөлтийн хувьд экстрополяци (төсөөлөн тооцолт) хийх замаар уг хамгийн сүүлийн төсөв/прогнозонд хамаарах тайлант үеэс хойшхи хугацааны мөнгөн гүйлгээний төсөвлөлтийг тооцоолно. Арай өндөр хувь хэмжээ зохистой гэдгийг баталж чадахаас бусад тохиолдолд энэхүү өсөлтийн хувь хэмжээ нь уг байгууллагын үйлдвэрлэдэг бүтээгдэхүүн, түүний үйл ажиллагаагаа явуулдаг салбар, улс буюу улс орнууд, эсвэл тухайн хөрөнгийг ашигладаг зах зээлийн урт хугацааны өсөлтийн дундаж хувиас илүүгүй байна.**

47. Өмнөх мөнгөн гүйлгээний төсөвлөлт ба гүйцэтгэлийн мөнгөн гүйлгээний хоорондох зөрүүгийн шалтгааныг хянаж үзсэнээр удирдлага нь өөрийн одоогийн мөнгөн гүйлгээний төсөвлөлтийн үндэслэл болж буй таамаглалуудын ул үндэслэлтэй байдлыг үнэлдэг. Өмнөх гүйцэтгэлийн мөнгөн гүйлгээг үүсэх үед оршин байгаагүй дараагийн үйл явдал буюу нөхцөл байдлын үр нөлөө нь хэрэв саад учруулахааргүй бол одоогийн мөнгөн гүйлгээний төсөвлөлтийн үндэслэл болж буй таамаглалууд нь уг өмнөх гүйцэтгэлийн үр дүнтэй нийцэн тохирох эсэхийг удирдлага нь ханган магадална.
48. Таван жилээс урт хугацааны ирээдүйн мөнгөн гүйлгээний нарийвчилсан, ил тодорхой, найдвартай санхүүгийн төсөв/прогноз ерөнхийдөө бэлэн, боломжтой байдаггүй. Энэ шалтгааны улмаас ирээдүйн мөнгөн гүйлгээний талаархи удирдлагын тооцоолол нь хамгийн уртдаа таван жилийн хугацааг хамрах хамгийн сүүлийн төсөв/прогнозод үндэслэдэг. Хэрэв удирдлага нь таван жилээс урт хугацааны уг төсөвлөлт найдвартай гэдэгт итгэлтэй байгаа бөгөөд ийм урт хугацааны мөнгөн гүйлгээг үнэн зөв таамаглах түүний боломжит байдлыг өмнөх туршлагадаа үндэслэн харуулж чадаж байвал таван жилээс урт хугацааны санхүүгийн төсөв/прогнозод үндэслэсэн мөнгөн гүйлгээний төсөвлөлтийг ашиглаж болно.
49. Санхүүгийн төсөв/прогнозод үндэслэсэн мөнгөн гүйлгээний төсөвлөлтөнд дараагийн жилүүдийн өсөлтийн хувь хэмжээг ашиглан экстраполяци хийх замаар тухайн хөрөнгийн ашиглалтын хугацааны эцэс хүртэлх мөнгөн гүйлгээний төсөвлөлтийг тооцоолдог. Өсөлтийн хувь хэмжээг нэмэгдүүлэх нь тухайн бүтээгдэхүүн буюу салбарын мөчлөгийн хэв загварын талаархи мэдээлэлтэй нийцэн тохирч байхаас бусад тохиолдолд өсөлтийн хувь нь тогтмол буюу буурах хувь хэмжээ байна. Хэрэв тохиромжтой бол өсөлтийн хувийг тэг эсвэл сөрөг гэж үзнэ.
50. Нөхцөл байдал тааламжтай үед өрсөлдөгч нар зах зээлд орж, өсөлтийг хязгаарлах магадлалтай байдаг. Иймээс байгууллага нь өөрийн үйлдвэрлэдэг бүтээгдэхүүн, үйл ажиллагаагаа явуулдаг салбар, улс буюу

улс орнууд, эсвэл тухайн хөрөнгийг ашигладаг зах зээлийн урт хугацаан дахь (жишээлбэл; хорин жил) түүхэн өсөлтийн дундаж хувийг давуулан биелүүлэхэд түвэгтэй байдаг.

51. Санхүүгийн төсөв/прогнозын мэдээллийг ашиглахдаа, байгууллага нь тухайн мэдээлэл ул үндэслэлтэй, дэмжигдэхүйц таамаглалыг тусгасан бөгөөд хөрөнгийн үлдсэн ашиглалтын хугацааны туршид оршин байх эдийн засгийн цогц нөхцөл байдлын талаархи удирдлагын хамгийн сайн тооцооллыг төлөөлөн илэрхийлж байгаа эсэхийг харгалзан үзнэ.

*Ирээдүйн мөнгөн гүйлгээний тооцооллын бүрэлдэхүүн*

52. **Ирээдүйн мөнгөн гүйлгээний тооцоолол нь дараах зүйлсийг багтаасан байна:**

- (а) **Тухайн хөрөнгийн тасралтгүй ашиглалтаас бий болох мөнгөн орлогын гүйлгээний төсөвлөлт;**
- (б) **Тухайн хөрөнгийн тасралтгүй ашиглалтаас бий болох мөнгөн орлогын гүйлгээг үүсгэхийн тулд зайлшгүй гарган зарцуулах ба уг хөрөнгөнд шууд хамааруулах буюу ул үндэслэлтэй, тууштай сууриар хуваарилж болох мөнгөн зарлагын гүйлгээний (үүнд хөрөнгийг ашиглахад бэлтгэх мөнгөн зарлагын гүйлгээ хамаарна) төсөвлөлт; ба**
- (в) **Хөрөнгийг түүний ашиглалтын хугацааны эцэст данснаас хассанаар хүлээн авах (эсвэл төлөх) аливаа цэвэр мөнгөн гүйлгээ.**

53. Ирээдүйн мөнгөн гүйлгээ болон дискаунтын хувь хэмжээний тооцоолол нь ерөнхий инфляцид хамаарах үнийн өсөлтийн талаархи тогтвортой таамаглалуудыг тусгасан байна. Иймээс дискаунтын хувь нь ерөнхий инфляцид хамаарах үнийн өсөлтийн үр нөлөөг тусгадаг бол ирээдүйн мөнгөн гүйлгээг нэрлэсэн дүнгээр тооцоолно. Хэрэв дискаунтын хувь нь ерөнхий инфляцид хамаарах үнийн өсөлтийн үр нөлөөг тусгаагүй бол ирээдүйн мөнгөн гүйлгээг бодит дүнгээр тооцоолно (гэхдээ ирээдүйн үнийн тусгай өсөлт буюу бууралтыг тусгана).

54. Мөнгөн зарлагын гүйлгээний төсөвлөлт нь тухайн хөрөнгийн өдөр тутмын ашиглалт, үйлчилгээний мөнгөн зарлага, түүнчлэн уг хөрөнгийн ашиглалтанд шууд хамааруулах эсвэл ул үндэслэлтэй, тууштай сууриар хуваарилж болох ирээдүйн нэмэлт мөнгөн зарлагыг багтаасан байна.

55. Хөрөнгийн дансны үнэ нь тухайн хөрөнгийг ашиглах эсвэл борлуулахад бэлэн болгохын өмнө гаргах бүх мөнгөн зарлагыг хараахан багтаагаагүй байгаа тохиолдолд ирээдүйн мөнгөн зарлагын гүйлгээний тооцоолол нь уг хөрөнгийг ашиглахад эсвэл борлуулахад бэлэн болгохоос өмнө гарахаар хүлээгдэж буй аливаа цаашдын мөнгөн зарлагын гүйлгээг багтаасан байна. Жишээлбэл; дуусаагүй барилгын ажил эсвэл хараахан хэрэгжиж дуусаагүй байгаа хөгжүүлэлтийн төсөл нь үүнд хамаарна.

56. Давхардуулж тооцохоос зайлсхийхийн тулд ирээдүйн мөнгөн гүйлгээний тооцоололд дараах зүйлсийг оруулахгүй:
- (а) Тухайн авч үзэж буй хөрөнгө (жишээлбэл; авлага гэх мэт санхүүгийн хөрөнгө)-өөс орох мөнгөний орлогоос бүрэн хамааралгүй байдлаар мөнгөн орлогын гүйлгээг бий болгодог хөрөнгөөс орох мөнгөн орлогын гүйлгээ; ба
  - (б) Өр төлбөр (жишээлбэл; өглөг, тэтгэврийн өглөг, нөөц)-өөр хүлээн зөвшөөрсөн үүрэгтэй холбоотой мөнгөн зарлагын гүйлгээ.
57. **Ирээдүйн мөнгөн гүйлгээг тухайн хөрөнгийн хувьд түүний одоогийн нөхцөл байдлаар тооцоолно. Ирээдүйн мөнгөн гүйлгээний тооцоололд дараах зүйлсээс бий болохоор хүлээгдэж буй тооцоолсон ирээдүйн мөнгөн орлогын буюу мөнгөн зарлагын гүйлгээг оруулахгүй:**
- (а) **Байгууллага нь хийх үүргийг хараахан хүлээгээгүй байгаа ирээдүйн бүтцийн өөрчлөлт; эсвэл**
  - (б) **Хөрөнгийн гүйцэтгэлийг сайжруулах буюу нэмэгдүүлэх.**
58. Ирээдүйн мөнгөн гүйлгээг тухайн хөрөнгийн хувьд түүний одоогийн нөхцөл байдлаар тооцоолдог учраас ашиглалтын үнэ цэнэд доорх зүйлсийг тусгахгүй:
- (а) Байгууллага нь хийх үүргийг хараахан хүлээгээгүй байгаа ирээдүйн бүтцийн өөрчлөлтөөс бий болохоор хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн зарлагын гүйлгээ эсвэл холбогдох өртгийн хэмнэлт (жишээлбэл; боловсон хүчний зардлыг бууруулах) буюу өгөөж;
  - (б) Хөрөнгийн гүйцэтгэлийг нэмэгдүүлэх буюу сайжруулахтай холбогдсон ирээдүйн мөнгөн зарлагын гүйлгээ эсвэл ийм зарлагын гүйлгээнээс бий болохоор хүлээгдэж буй холбогдох мөнгөн орлогын гүйлгээ.
59. Бүтцийн өөрчлөлт гэдэг нь (а) удирдлага төлөвлөж, хянадаг, бөгөөд (б) байгууллагын эрхэлдэг үйл ажиллагааны цар хүрээ эсвэл тэдгээр үйл ажиллагааг явуулж буй арга хэлбэрийг материаллагаар өөрчлөх хөтөлбөр юм. УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө* нь бүтцийн өөрчлөлт хийх үүргийг байгууллага хэзээ хүлээж буйг тодорхойлох заавар удирдамжийг тусгасан байдаг.
60. Байгууллага нь бүтцийн өөрчлөлт хийх үүрэг хүлээсэн тохиолдолд энэхүү бүтцийн өөрчлөлт нь зарим хөрөнгөнд нөлөөлөх магадлалтай байдаг. Байгууллага нь бүтцийн өөрчлөлт хийх үүрэг хүлээмэгц:
- (а) Хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг тодорхойлох зорилгоор хийсэн ирээдүйн мөнгөн орлогын болон мөнгөн зарлагын гүйлгээний тооцоолол нь уг бүтцийн өөрчлөлтөөс бий болох (удирдлагын баталсан хамгийн сүүлийн санхүүгийн төсөв/прогнозод үндэслэсэн) өртгийн хэмнэлт болон бусад өгөөжийг тусгадаг;

- (б) Бүтцийн өөрчлөлтийн хувьд гарах ирээдүйн мөнгөн зарлагын гүйлгээний тооцооллыг УСНББОУС 19-ийн дагуу уг бүтцийн өөрчлөлтийн нөөцөд тусган оруулна.
61. Байгууллага нь хөрөнгийн гүйцэтгэлийг сайжруулах буюу нэмэгдүүлэх тийм мөнгөн зарлагын гүйлгээг гаргах хүртэл уг мөнгөн зарлагын гүйлгээтэй холбоотойгоор нэмэгдэх эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхиас үүсэхээр хүлээгдэж буй тооцоолсон ирээдүйн мөнгөн орлогын гүйлгээг тухайн ирээдүйн мөнгөн гүйлгээний тооцоололд оруулахгүй.
62. Хөрөнгийн одоогийн нөхцөл байдалд уг хөрөнгөөс бий болохоор хүлээгдэж буй эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийн түвшинг хэвийн хадгалахад шаардлагатай ирээдүйн мөнгөн зарлагын гүйлгээг уг ирээдүйн мөнгөн гүйлгээний тооцоололд оруулна. Мөнгө бий болгогч нэгж нь тооцоолсон өөр өөр ашиглалтын хугацаа бүхий хөрөнгүүдээс бүрддэг бөгөөд тэдгээр нь бүгд тухайн нэгжийн тасралтгүй үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой байх тохиолдолд нэг хөрөнгийг арай богино ашиглалтын хугацаатай өөр хөрөнгөөр сольж орлуулалтыг уг нэгжтэй холбоотой ирээдүйн мөнгөн гүйлгээг тооцоолох үедээ тухайн нэгжийн өдөр тутмын ашиглалт, үйлчилгээний нэг хэсэг гэж үзнэ. Үүнтэй адилаар, нэг хөрөнгө нь тооцоолсон өөр өөр ашиглалтын хугацаа бүхий бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрддэг тохиолдолд нэг бүрэлдэхүүн хэсгийг арай богино ашиглалтын хугацаатай өөр бүрэлдэхүүн хэсгээр сольж орлуулалтыг уг хөрөнгөөс бий болох ирээдүйн мөнгөн гүйлгээг тооцоолох үедээ тухайн хөрөнгийн өдөр тутмын ашиглалт, үйлчилгээний нэг хэсэг гэж үзнэ.
63. **Ирээдүйн мөнгөн гүйлгээний тооцоололд дараах зүйлс хамаарахгүй:**
- (а) **Санхүүжилтийн үйл ажиллагааны мөнгөн орлогын буюу мөнгөн зарлагын гүйлгээ; эсвэл**
- (б) **Орлогын татварт төлсөн эсвэл хүлээн авсан мөнгө.**
64. Тооцоолсон ирээдүйн мөнгөн гүйлгээ нь дискаунтын хувийг тодорхойлдог арга замтай нийцэн уялдах тийм таамаглалуудыг тусгадаг. Ингэж уялдахгүй бол зарим таамаглалуудын үр нөлөөг давхардуулж тооцох эсвэл огт тооцохгүй орхигдуулах юм. Тооцоолсон ирээдүйн мөнгөн гүйлгээг дискаунтчилсанаар мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг харгалзан үздэг тул эдгээр мөнгөн гүйлгээнд санхүүжилтийн үйл ажиллагааны мөнгөн орлого буюу мөнгөн зарлагын гүйлгээг оруулахгүй. Үүнтэй адилаар, дискаунтын хувийг татварын өмнөх сууриар тодорхойлдог тул ирээдүйн мөнгөн гүйлгээг мөн татварын өмнөх сууриар тодорхойлно.
65. **Хөрөнгийг түүний ашиглалтын хугацааны эцэст данснаас хассанаар хүлээн авах (эсвэл төлөх) цэвэр мөнгөн гүйлгээний тооцоолол нь зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хоорондох харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр уг хөрөнгийн данснаас хасалтаас олж авахаар байгууллагын хүлээж**

**буй, тухайн данснаас хасалтын тооцоолсон зардлыг хассаны дараах дүн байна.**

66. Хөрөнгийг түүний ашиглалтын хугацааны эцэст данснаас хассанаар хүлээн авах (эсвэл төлөх) цэвэр мөнгөн гүйлгээг дараах байдлаар тооцогоос бусад тохиолдолд тухайн хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийг тооцохтой ижил арга замаар тодорхойлно:
- (а) Тухайн хөрөнгийг ашиглах нөхцөлтэй ижил нөхцлөөр ашиглагдаж байсан бөгөөд өөрийн ашиглалтын хугацааны эцэст хүрсэн ижил төсөөтэй хөрөнгийн тэрхүү тооцооллын өдрөөрх зонхилох үнийг уг байгууллага нь ашигладаг.
  - (б) Байгууллага нь ерөнхий инфляцийн улмаас үүсэх ирээдүйн үнийн өсөлт ба тусгай үнийн ирээдүйн өсөлт буюу бууралтын аль алины үр нөлөөний хувьд тэдгээр зонхилох үнийг тохируулна. Гэхдээ тухайн хөрөнгийн тасралтгүй ашиглалтаас үүсэх ирээдүйн мөнгөн гүйлгээний тооцоолол болон дискаунтын хувьд ерөнхий инфляцийн үр нөлөөг харгалзан тусгадаггүй бол уг байгууллага нь хөрөнгийн данснаас хасалтын цэвэр мөнгөн гүйлгээнд энэхүү үр нөлөөг мөн харгалзан тусгахгүй.

*Гадаад валютаарх ирээдүйн мөнгөн гүйлгээ*

67. Ирээдүйн мөнгөн гүйлгээг түүний үүсэн бий болох валютаар тооцоолох ба үүний дараа уг валютанд тохиромжтой дискаунтын хувийг ашиглан дискаунтчилна. Байгууллага нь ашиглалтын үнэ цэнийг тооцоолох өдрийн спот ханшийг ашиглан уг өнөөгийн үнэ цэнийг хөрвүүлнэ.

*Дискаунтын хувь*

68. **Дискаунтын хувь (хувиуд) нь дараах зүйлсийн одоогийн зах зээлийн үнэлгээг тусгасан татварын өмнөх хувь хэмжээ (хувь хэмжээнүүд) байна:**
- (а) **Эрсдэлгүй хүүний одоогийн хувь хэмжээгээр илэрхийлэгдэх мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ; ба**
  - (б) **Уг эрсдлийн хувьд ирээдүйн мөнгөн гүйлгээний тооцооллыг тохируулаагүй байгаа бөгөөд тухайн хөрөнгөнд тусгайлан хамаарах эрсдэл.**
69. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ, түүнчлэн тухайн хөрөнгөнд тусгайлан хамаарах эрсдлийн одоогийн зах зээлийн үнэлгээг тусгасан хувь хэмжээ нь байгууллага уг хөрөнгөөс олохоор хүлээж буй мөнгөн гүйлгээтэй ижил дүн, хугацаа, эрсдэл бүхий мөнгөн гүйлгээг бий болгох тийм хөрөнгө оруулалтын хувилбарыг тухайн хөрөнгө оруулагч сонгосон бол түүний шаардах байсан тэр өгөөж юм. Ижил төсөөтэй хөрөнгүүдийн одоогийн зах зээлийн арилжаанд нуугдмал агуулагдаж буй хувь хэмжээгээр энэхүү хувь хэмжээг тооцоолно. Гэхдээ хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг хэмжихэд ашиглах дискаунтын хувь нь тухайн эрсдлийн хувьд ирээдүйн мөнгөн

гүйлгээний тооцооллыг тохируулсан тийм эрсдлийг тусган илэрхийлэхгүй. Хэрэв ингэж тусгавал зарим таамаглалуудын үр нөлөөг давхар тооцоход хүргэх юм.

70. Хөрөнгөнд тусгайлан хамаарах хувь хэмжээг тухайн зах зээлээс шууд тодорхойлох боломжгүй тохиолдолд байгууллага нь дискаунтын хувийг тооцохдоо орлох зүйлсийг ашиглана. Мөрдөх заавар удирдамж нь ийм нөхцөл байдалд дискаунтын хувийг тооцоолох талаархи нэмэлт заавар удирдамжаар хангадаг.

### **Үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөх ба хэмжих**

71. Гүүдвилээс бусад, бие даасан хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөх ба хэмжих шаардлагуудыг 72-75-р параграфт заасан. Мөнгө бий болгогч нэгж болон гүүдвиллийн хувьд үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөх ба хэмжих талаар 76-98И параграфт авч үзсэн.
72. **Хөрөнгийн нөхөгдөх дүн нь түүний дансны үнээс бага байх зөвхөн тийм тохиолдолд тухайн хөрөнгийн дансны үнийг түүний нөхөгдөх дүн хүртэл бууруулна. Ийм бууралт нь үнэ цэнийн бууралтын гарз юм.**
73. **Хөрөнгийг өөр бусад Стандартын (жишээлбэл, УСНББОУС 17 ба УСНББОУС 31-д заасан дахин үнэлгээний загварын) дагуу дахин үнэлсэн дүнгээр бүртгэснээс бусад тохиолдолд үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдалд шууд хүлээн зөвшөөрнө. Дахин үнэлсэн хөрөнгийн аливаа үнэ цэнийн бууралтын гарзыг уг бусад Стандартын дагуу дахин үнэлгээний бууралт гэж үзнэ.**
- 73А. Дахин үнэлээгүй хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Харин дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз нь тухайн хөрөнгийн ангийн дахин үнэлгээний нэмэгдлийн дүнгээс хэтрэхгүй байх тэр хэмжээ хүртэл үнэ цэнийн бууралтын гарзыг дахин үнэлгээний нэмэгдэлд хүлээн зөвшөөрнө. Дахин үнэлсэн хөрөнгийн ийм үнэ цэнийн бууралтын гарз нь тухайн хөрөнгийн ангийн хувьд дахин үнэлгээний нэмэгдлийг бууруулна.
74. **Үнэ цэнийн бууралтын гарзын хувьд тооцоолсон дүн нь холбогдох хөрөнгийнхөө дансны үнээс илүү байх тохиолдолд байгууллага нь зөвхөн бусад Стандартаар шаардсан бол зөрүүг өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.**
75. **Үнэ цэнийн бууралтын гарзын хүлээн зөвшөөрөлтийн дараа, уг хөрөнгийн үлдэх өртгийг (хэрэв байгаа бол) хассан, түүний хянан засварласан дансны үнийг тухайн хөрөнгийн үлдсэн ашиглалтын хугацаанд системтэйгээр хуваарилахын тулд хөрөнгийн элэгдлийн (хорогдуулгын) зардлыг ирээдүйн тайлант үедэд тохируулна.**

## Мөнгө бий болгогч нэгжүүд ба гүүдвил

76. Хөрөнгийн харъяалагдах мөнгө бий болгогч нэгжийг тогтоох, уг мөнгө бий болгогч нэгжүүд болон гүүдвиллийн дансны үнийг тодорхойлох, тэдгээрийн хувьд үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөх талаархи шаардлагуудыг 77-97И параграфт тусгасан.

### Хөрөнгийн харъяалагдах мөнгө бий болгогч нэгжийг тогтоох

77. **Хэрэв хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болох ямар нэг шинж тэмдэг байгаа бол тухайн бие даасан хөрөнгийн хувьд түүний нөхөгдөх дүнг тооцоолно. Хэрэв бие даасан хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцоолох боломжгүй бол байгууллага нь уг хөрөнгийн харъяалагдах мөнгө бий болгогч нэгжийн (хөрөнгийн мөнгө бий болгогч нэгжийн) нөхөгдөх дүнг тодорхойлно.**

78. Бие даасан хөрөнгийн нөхөгдөх дүнг дараах тохиолдолд тодорхойлох боломжгүй байдаг:

- (а) Хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг түүний борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэтэй ойролцоо байхаар тооцоолж чадахгүй (жишээлбэл; хөрөнгийн тасралтгүй ашиглалтаас үүсэх ирээдүйн мөнгөн гүйлгээ өчүүхэн бага байна гэдгийг тооцоолох боломжгүй байх); ба
- (б) Тухайн хөрөнгө нь бусад хөрөнгүүдийн мөнгөн орлогоос бүрэн хамааралгүй байдлаар мөнгөн орлогыг бий болгодоггүй бөгөөд мөнгөн орлогыг бие даасан байдлаар бий болгож чадахгүй.

Ийм тохиолдолд ашиглалтын үнэ цэнийг, улмаар нөхөгдөх дүнг зөвхөн уг хөрөнгийн мөнгө бий болгогч нэгжийн хувьд тодорхойлж болох юм.

79. 13-р параграфт тодорхойлсончлон, хөрөнгийн мөнгө бий болгогч нэгж нь (а) тухайн хөрөнгийг өөртөө агуулсан, (б) бусад хөрөнгө буюу хөрөнгүүдийн бүлгийн мөнгөн орлогоос бүрэн хамааралгүй байдлаар мөнгөн орлогыг бий болгодог хөрөнгүүдийн хамгийн бага бүлэг юм. Хөрөнгийн мөнгө бий болгогч нэгжийг тодорхойлохдоо шүүн тунгаалт хийдэг. Хэрэв бие даасан хөрөнгийн хувьд түүний нөхөгдөх дүнг тодорхойлох боломжгүй бол байгууллага нь бүрэн хамааралгүй байдлаар мөнгөн орлогыг бий болгодог хөрөнгийн хамгийн бага нэгдлийг тодорхойлно.
80. Мөнгөн орлогын гүйлгээ нь тухайн байгууллагын хувьд гаднын байх талуудаас хүлээн авах мөнгө ба мөнгөтэй адилтгах зүйлсийн орлогын гүйлгээ юм. Хөрөнгөөс (эсвэл хөрөнгүүдийн бүлгээс) орох мөнгөн орлогын гүйлгээ нь бусад хөрөнгийн (буюу хөрөнгүүдийн бүлгийн) мөнгөн орлогоос бүрэн хамааралгүй эсэхийг тогтоохдоо, байгууллага нь янз бүрийн хүчин зүйлсийг харгалзан үздэг. Үүнд: удирдлага нь (а) тухайн байгууллагын үйл ажиллагааг хэрхэн (бүтээгдэхүүний төрлөөр, бизнесийн үйл ажиллагаагаар, тодорхой байршлаар, дүүргээр эсвэл бүс нутгаар) хянан үнэлдэг, эсвэл (б) тухайн байгууллагын хөрөнгө болон үйл ажиллагааг

үргэлжлүүлэн ашиглах буюу данснаас хасах талаархи шийдвэрийг хэрхэн гаргадаг эсэх гэх мэт. Мөнгө бий болгогч нэгжийг тодорхойлох жишээг Хэрэгжүүлэх заавар удирдамжинд харуулсан.

81. **Хөрөнгө буюу хөрөнгүүдийн бүлгийн үйлдвэрлэдэг бүтээгдэхүүний хувьд идэвхитэй зах зээл оршин байгаа бол хэдийгээр тэдгээр бүтээгдэхүүний заримыг эсвэл бүгдийг дотооддоо ашигладаг байлаа ч гэсэн тухайн хөрөнгө буюу хөрөнгүүдийн бүлгийг мөнгө бий болгогч нэгж гэж тодорхойлно. Аль нэг хөрөнгө эсвэл мөнгө бий болгогч нэгжийн үүсгэн бий болгох мөнгөн орлогын гүйлгээнд дотоод үнэ шилжилт нөлөө үзүүлдэг бол дараах зүйлсийг тооцоолохдоо байгууллага нь харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр бий болох ирээдүйн үнийн талаархи удирдлагын хамгийн сайн тооцооллыг ашиглана:**
- (a) **Тухайн хөрөнгө эсвэл мөнгө бий болгогч нэгжийн ашиглалтын үнэ цэнийг тодорхойлоход ашиглах ирээдүйн мөнгөн орлогын гүйлгээ; ба**
  - (b) **Дотоод үнэ шилжилтээр нөлөө үзүүлдэг аливаа бусад хөрөнгө буюу мөнгө бий болгогч нэгжийн ашиглалтын үнэ цэнийг тодорхойлоход ашиглах ирээдүйн мөнгөн зарлагын гүйлгээ.**
82. Хөрөнгө буюу хөрөнгүүдийн бүлгийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний зарим хэсгийг эсвэл бүгдийг (жишээлбэл; үйлдвэрлэлийн процессын дундын шатан дахь бүтээгдэхүүнийг) уг байгууллагын бусад нэгжүүд ашигладаг боловч тухайн байгууллага нь тэрхүү бүтээгдэхүүнийг идэвхитэй зах зээлд худалдан борлуулж чадах бол энэхүү хөрөнгө буюу хөрөнгүүдийн бүлэг нь мөнгө бий болгогч тусдаа нэгжийг бүрдүүлэх юм. Яагаад гэвэл, энэхүү хөрөнгө буюу хөрөнгүүдийн бүлэг нь бусад хөрөнгө буюу хөрөнгүүдийн бүлгийн мөнгөн орлогоос бүрэн хамааралгүй байдлаар мөнгөн орлогыг бий болгож чадаж байна. Ийм мөнгө бий болгогч нэгж буюу аливаа бусад хөрөнгөтэй, эсвэл дотоод үнэ шилжилт нөлөө үзүүлдэг мөнгө бий болгогч нэгжтэй холбоотой санхүүгийн төсөв/прогнозод үндэслэсэн мэдээллийг ашиглахдаа, байгууллага нь хэрэв харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр тогтоож болох байсан ирээдүйн үнийн талаархи удирдлагын хамгийн сайн тооцооллыг уг дотоод үнэ шилжилтэнд тусгаагүй бол энэхүү мэдээллийг тохируулна.
83. **Мөнгө бий болгогч нэгжүүдийг тухайн нэг хөрөнгө буюу хөрөнгүүдийн бүлгийн хувьд өөрчлөх хэрэгтэй гэдгийг зөвтгөн батлахаас бусад тохиолдолд нэг тайлант үеэс дараагийн тайлант үед тогтвортой тодорхойлно.**
84. Хэрэв мөнгө бий болгогч нэгжид харъяалагдах хөрөнгө нь өмнөх тайлант үеэс өөрчлөгдсөн эсвэл тухайн хөрөнгийн мөнгө бий болгогч нэгжид нэгтгэгдэн харъяалагдах хөрөнгийн төрөл өөрчлөгдсөн гэдгийг уг байгууллага тодорхойлсон бөгөөд энэхүү мөнгө бий болгогч нэгжийн хувьд үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрсөн эсвэл буцаасан



бол уг мөнгө бий болгогч нэгжийн талаар тодруулга хийхийг 120-р параграфтаар шаардсан байдаг.

**Мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүн ба дансны үнэ**

85. Мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүн нь тухайн мөнгө бий болгогч нэгжийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ ба түүний ашиглалтын үнэ цэнийн аль өндөр дүн юм. Мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүнг тодорхойлох зорилгын хувьд 31-70-р параграф дахь “хөрөнгө” гэсэн аливаа хэллэгийг “мөнгө бий болгогч нэгж” гэсэн утгаар ойлгож хэрэглэнэ.

86. **Мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүнг тодорхойлох арга замтай нийцэх тийм сууриар тухайн мөнгө бий болгогч нэгжийн дансны үнийг тодорхойлно.**

87. Мөнгө бий болгогч нэгжийн дансны үнэ нь:

(а) Тухайн мөнгө бий болгогч нэгжид шууд хамааруулах буюу ул үндэслэлтэй, тогтвортой сууриар түүнд хуваарилагдах ба уг мөнгө бий болгогч нэгжийн ашиглалтын үнэ цэнийг тодорхойлоход ашиглах ирээдүйн мөнгөн орлогын гүйлгээг бий болгох зөвхөн тэдгээр хөрөнгийн дансны үнийг багтаасан байна; ба

(б) Тухайн өр төлбөрийг харгалзан үзэхгүйгээр уг мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүнг тодорхойлж чадахгүй байхаас бусад тохиолдолд аливаа хүлээн зөвшөөрсөн өр төлбөрийн дансны үнийг өөртөө агуулаагүй байна.

Яагаад гэвэл, мөнгө бий болгогч нэгжийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ ба ашиглалтын үнэ цэнийг тодорхойлохдоо, тухайн мөнгө бий болгогч нэгжийн нэг хэсэг болохгүй хөрөнгө болон хүлээн зөвшөөрсөн өр төлбөртэй холбоотой мөнгөн гүйлгээг харгалзан үздэггүй (41 ба 56-р параграфыг үзнэ үү).

88. Нөхөгдөх дүнг үнэлэх зорилгоор хөрөнгүүдийг бүлэглэдэг тохиолдолд, холбогдох мөнгөн орлогын гүйлгээг бий болгодог буюу ингэж бий болгоход ашиглагдах бүх хөрөнгүүдийг уг мөнгө бий болгогч нэгжид багтаан оруулах нь чухал ач холбогдолтой юм. Хэрэв тэгэхгүй бол тухайн мөнгө бий болгогч нэгж нь бүрэн нөхөгдөх мэт харагдах боловч үнэн хэрэгтээ үнэ цэнийн бууралтын гарз үүссэн байж болох юм. Мөнгө бий болгогч нэгжийн нэг хэсэг болох бие даасан хөрөнгүүдийн тайлагналыг үлгэрчлэн харуулсан блок схемийг Үлгэрчилсэн Шийдвэрийн Модонд харуулсан. Зарим тохиолдолд хэдийгээр тодорхой хөрөнгүүд нь мөнгө бий болгогч нэгжийн тооцоолсон ирээдүйн мөнгөн гүйлгээнд хувь нэмрээ оруулдаг боловч тэдгээрийг ул үндэслэлтэй, тогтвортой сууриар уг мөнгө бий болгогч нэгжид хуваарилах боломжгүй байдаг. Гүүдвэлийн хувьд ийм тохиолдол үүсэж болно. Мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтыг сорьж шалгах үедээ эдгээр хөрөнгийг хэрхэн авч үзэхийг 90А-90Р параграфт тайлбарласан.

89. Хүлээн зөвшөөрсөн зарим өр төлбөрийг уг мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүнг тодорхойлохдоо харгалзан үзэх шаардлагатай байж болох юм. Мөнгө бий болгогч нэгжийн данснаас хасалт нь өр төлбөрийг хариуцахыг тухайн худалдан авагчаас шаарддаг бол ийм тохиолдол үүсэж болно. Энэ тохиолдолд мөнгө бий болгогч нэгжийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ (буюу эцсийн данснаас хасалтаас үүсэх тооцоолсон мөнгөн гүйлгээ) нь уг мөнгө бий болгогч нэгжийн хөрөнгө, өр төлбөрийг хамтад нь борлуулах тооцоолсон үнээс тухайн данснаас хасалтын зардлыг хассан дүн байна. Мөнгө бий болгогч нэгжийн дансны үнэ ба түүний нөхөгдөх дүнгийн хооронд ач холбогдолтой зэрэгцүүлэлт хийхийн тулд уг мөнгө бий болгогч нэгжийн ашиглалтын үнэ цэнэ болон түүний дансны үнийн аль алиныг тодорхойлохдоо өр төлбөрийн дансны үнийг хасдаг.
90. Практик шалтгаанаар зарим тохиолдолд мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүнг (а) уг мөнгө бий болгогч нэгжийн нэг хэсэг болохгүй хөрөнгө (жишээлбэл; авлага буюу бусад санхүүгийн хөрөнгө), эсвэл (б) хүлээн зөвшөөрсөн өр төлбөр (жишээлбэл; өглөг, тэтгэврийн өглөг, бусад нөөц)-ийг харгалзан үзсэний дараах байдлаар тодорхойлдог. Ийм тохиолдолд мөнгө бий болгогч нэгжийн дансны үнийг тэдгээр хөрөнгийн дансны үнээр нэмэгдүүлэх ба өр төлбөрийн дансны үнээр бууруулна.

#### *Гүүдвил*

Мөнгө бий болгогч нэгжүүдэд гүүдвилийг хуваарилах

- 90А. **Үнэ цэнийн бууралтын сорил хийх зорилгын хувьд, улсын секторын нэгдлээр олж эзэмшсэн гүүдвилийг уг нэгдлийн өргөжилтийн хэмнэлтээс үр өгөөж олохоор хүлээгдэж буй тухайн нэгтгэгчийн мөнгө бий болгогч нэгж буюу мөнгө бий болгогч нэгжүүдийн бүлэг нэг бүрд тэрхүү худалдан авалтын өдрөөс эхлэн хуваарилна. Энэ нь тухайн нэгдэж буй үйл ажиллагааны бусад хөрөнгө буюу өр төлбөрийг тэдгээр мөнгө бий болгогч нэгж буюу нэгжүүдийн бүлэгт хуваарилсан эсэхээс үл хамаарна. Мөнгө бий болгодоггүй үйл ажиллагааны худалдан авалтаар гүүдвилийг олж эзэмшсэн бөгөөд энэ нь нэгтгэгчийн цэвэр мөнгөн зарлагыг бууруулах үр дүнтэй байх тохиолдолд уг нэгтгэгчийг мөнгө бий болгогч нэгж гэж үзнэ. Гүүдвил нь мөнгө бий болгодоггүй үйл ажиллагааны худалдан авалттай холбоотой байхаас бусад тохиолдолд уг гүүдвилийг ингэж хуваарилах нэгж буюу нэгжүүдийн бүлэг нэг бүр нь:**
- (а) **дотоод удирдлагын зорилгоор уг гүүдвилийг хянан үнэлэх тухайн байгууллагын доторх хамгийн доод түвшинг төлөөлөн илэрхийлнэ; ба**
  - (б) **УСНББОУС 18, *Сегментийн Тайлагнал*-ын 9-р параграфтаар тодорхойлсон, сегментээс том биш байна.**
- 90Б. Худалдан авалтаар хүлээн зөвшөөрсөн гүүдвил нь тухайн нэгдлээр олж эзэмшсэн бусад хөрөнгүүдээс бий болох бөгөөд бие даасан байдлаар

тодорхойлж, тусдаа хүлээн зөвшөөрөх боломжгүй эдийн засгийн үр өгөөжийг илэрхийлдэг хөрөнгө юм. Гүүдвил нь бусад хөрөнгө буюу хөрөнгүүдийн бүлгээс хамааралгүй байдлаар мөнгөн орлогын гүйлгээг бий болгохгүй эсвэл цэвэр мөнгөн зарлагын гүйлгээг бууруулахгүй боловч мөнгө бий болгогч олон нэгжүүдийн мөнгөн гүйлгээнд ямагт хувь нэмрээ оруулдаг. Зарим үед гүүдвилийг бие даасан мөнгө бий болгогч нэгжүүдэд санамсаргүй тохиолдлын шинжтэйгээс өөр бусад сууриар хуваарилах боломжгүй байдаг боловч мөнгө бий болгогч нэгжүүдийн бүлгүүдэд ингэж хуваарилах боломжтой юм. Иймээс дотоод удирдлагын зорилгоор гүүдвилийг хянан үнэлэх тухайн байгууллага доторх хамгийн доод түвшин нь уг гүүдвилд хамааралтай боловч гүүдвилийг хуваарилж болохгүй, мөнгө бий болгогч олон нэгжүүдээс зарим үед бүрддэг. Гүүдвилийг хуваарилах мөнгө бий болгогч нэгжийн талаархи 90Г-90Р болон 97А-97И параграф дахь хэллэгүүдийг гүүдвилийг хуваарилах мөнгө бий болгогч нэгжүүдийн бүлэг гэсэн утгаар ойлгож унших хэрэгтэй. Нэгтгэгчийн цэвэр мөнгөн зарлагын гүйлгээг бууруулах үр дүнтэй, мөнгө бий болгодоггүй үйл ажиллагааны худалдан авалтаар гүүдвилийг олж эзэмшсэн тохиолдолд гүүдвилийг хуваарилах мөнгө бий болгогч нэгжийн талаархи 90Г-90Р болон 97А-97И параграф дахь хэллэгүүдийг тухайн нэгтгэгч гэсэн утгаар бас ойлгож унших хэрэгтэй.

- 90В. 90А параграф дахь шаардлагуудыг даган мөрдөх нь байгууллага өөрийн үйл ажиллагааг удирдан зохицуулдаг болон угаасаа гүүдвилтэй холбоотой байх тийм арга замыг тусган илэрхийлэх түвшинд гүүдвилийн үнэ цэнийн бууралтыг сорьж шалгахад хүргэнэ. Иймээс тайлагналын нэмэлт системийг хөгжүүлэн боловсруулах үндсэндээ шаардлагагүй юм.
- 90Г. Үнэ цэнийн бууралтыг сорьж шалгах зорилгоор гүүдвилийг хуваарилах мөнгө бий болгогч нэгж нь гадаад валютын олз, гарзыг хэмжих зорилгоор УСНББОУС 4, *Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө*-ний дагуу гүүдвилийг хуваарилах түвшинтэй нийцэн тохирохгүй байж болно. Жишээлбэл; гадаад валютын олз, гарзыг хэмжих зорилгоор гүүдвилийг харьцангуй доод түвшингүүдэд хуваарилахыг УСНББОУС 4-өөр уг байгууллагаас шаарддаг байлаа гэхэд дотоод удирдлагын зорилгоор гүүдвилийг ийм түвшинд мөн хянан үнэлдэгээс бусад тохиолдолд үнэ цэнийн бууралтын зорилгоор гүүдвилийг үүнтэй ижил түвшинд сорьж шалгах шаардлагагүй юм.
- 90Д. **Хэрэв улсын секторын нэгдлээр олж эзэмшсэн гүүдвилийн анхны хуваарилалтыг тухайн нэгдлийн хүчин төгөлдөр болсон тайлант жилийн эцсээс өмнө бүрэн хийж чадаагүй бол нэгдлийн өдрөөс хойш эхлэх уг эхний тайлант жилийн эцэс болохоос өмнө тэрхүү анхны хуваарилалтыг хийж дуусгана.**
- 90Е. УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийн дагуу хэрэв уг нэгдлийн анхны нягтлан бодох бүртгэлийг тэрхүү нэгдэл хүчин төгөлдөр болсон тухайн тайлант үеийн эцсээр зөвхөн урьдчилсан нөхцөлт байдлаар тодорхойлж чадахаар бол нэгтгэгч нь:

- (a) Тэдгээр урьдчилсан нөхцөлт үнэ цэнийг ашигласнаар уг нэгдлийг тайлагнана; ба
- (б) Нэгдлийн өдрөөс хойш 12 сараас илүүгүй байх хэмжилтийн хугацааны дотор уг анхны нягтлан бодох бүртгэлийг хийж дуусгасны үр дүнд тэдгээр урьдчилсан нөхцөлт үнэ цэнэд хийгдэх аливаа тохируулгыг хүлээн зөвшөөрнө.

Ийм нөхцөл байдалд уг нэгдэл хүчин төгөлдөр болсон тайлант жилийн эцсээс өмнө тухайн нэгдлээр хүлээн зөвшөөрсөн гүүдвилийн анхны хуваарилалтыг мөн хийж дуусгах боломжгүй байж болно. Энэ тохиолдолд байгууллага нь 122А параграфтаар шаардсан мэдээллийг тодруулна.

**90Ж. Гүүдвилийг мөнгө бий болгогч нэгжид хуваарилсан бөгөөд байгууллага нь тухайн мөнгө бий болгогч нэгжид багтсан үйл ажиллагааг данснаас хассан бол уг данснаас хассан үйл ажиллагаатай холбоотой гүүдвил нь:**

- (a) Данснаас хасалтын олз, гарзыг тодорхойлох үед тухайн үйл ажиллагааны дансны үнэд багтана; ба
- (б) Тухайн данснаас хассан үйл ажиллагаатай холбоотой гүүдвилийг илүү сайн тусган илэрхийлэх өөр бусад аргыг уг байгууллага харуулж чадахгүй бол мөнгө бий болгогч нэгжийн үлдсэн хэсгийн болон данснаас хассан үйл ажиллагааны харгалзах харьцангуй үнэ цэнээр хэмжигдэнэ.

**90И. Хэрэв байгууллага нь гүүдвилийг хуваарилсан нэг буюу хэд хэдэн мөнгө бий болгогч нэгжүүдийн бүрэлдэхүүнийг өөрчлөх замаар өөрийн тайлагналын бүтцийг өөрчилж байгаа бол тэдгээр өөрчлөлтөнд орох нэгжүүдэд гүүдвилийг дахин хуваарилна. Байгууллага нь тухайн бүтцийн өөрчлөлт хийсэн нэгжүүдтэй холбоотой гүүдвилийг илүү сайн тусган илэрхийлэх өөр бусад арга замыг харуулж чадахгүй бол мөнгө бий болгогч нэгжийн доторх үйл ажиллагааг данснаас хасах үед хэрэглэсэнтэй адил харьцангуй үнэ цэнийн аргыг ашиглан энэхүү дахин хуваарилалтыг хийнэ.**

Гүүдвил бүхий мөнгө бий болгогч нэгжүүдийн үнэ цэнийн бууралтыг сорьж шалгах

**90К. 90Б параграфт дурдсанчлан, гүүдвил нь мөнгө бий болгогч нэгжтэй холбоотой боловч түүнийг тэрхүү нэгжид хуваарилаагүй байх үед уг нэгжийн үнэ цэнэ буурсан байж болох ямар нэг шинж тэмдэг байгаа бол аливаа гүүдвилийг агуулаагүй тухайн нэгжийн дансны үнийг түүний нөхөгдөх дүнтэй зэрэгцүүлснээр энэхүү нэгжийн үнэ цэнийн бууралтыг сорьж шалгана. Үнэ цэнийн бууралтын аливаа гарзыг 91-р параграфт заасны дагуу хүлээн зөвшөөрнө.**

**90Л. 90К параграфт дурдсан, мөнгө бий болгогч нэгж нь тодорхой бус ашиглалтын хугацаатай эсвэл ашиглахад хараахан бэлэн болоогүй байгаа биет бус хөрөнгийг өөрийн дансны үнэдээ агуулдаг бөгөөд тэрхүү хөрөнгийг зөвхөн уг мөнгө бий болгогч нэгжийн нэг хэсэг байдлаар үнэ**

цэнийн бууралтын хувьд сорьж шалгаж болохоор бол тухайн нэгжийн үнэ цэнийн бууралтыг мөн жил бүр сорьж шалгахыг 23-р параграфтаар шаардсан байдаг.

90М. Гүүдвилийг хуваарилсан мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнэ буурсан байж болох ямар нэг шинж тэмдэг байгаа тохиолдолд гүүдвилийг агуулсан тухайн нэгжийн дансны үнийг түүний нөхөгдөх дүнтэй зэрэгцүүлснээр уг нэгжийн үнэ цэнийн бууралтыг жил бүр сорьж шалгана. Хэрэв нэгжийн нөхөгдөх дүн нь түүний дансны үнээс илүү байвал уг нэгж, түүнчлэн түүнд хуваарилсан гүүдвилийн үнэ цэнэ буураагүй гэж үзнэ. Хэрэв нэгжийн дансны үнэ нь түүний нөхөгдөх дүнгээс илүү байвал байгууллага нь 91-р параграфын дагуу үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрнө.

Үнэ цэнийн бууралтын сорилын хугацаа

90Н. Хэрэв гүүдвилийг хуваарилсан мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтын жил тутмын сорилыг жил бүрийн тодорхой нэг ижил хугацаанд хийдэг бол жилийн турш дахь дурын хугацаанд үүнийг гүйцэтгэж болно. Харин мөнгө бий болгогч өөр өөр нэгжүүдийн үнэ цэнийн бууралтыг өөр өөр хугацаанд сорьж шалгаж болно. Гэхдээ мөнгө бий болгогч нэгжид хуваарилсан зарим буюу бүх гүүдвилийг тухайн тайлант жилийн туршид улсын секторын нэгдлээр олж авсан бол тэрхүү нэгжийн үнэ цэнийн бууралтыг тухайн тайлант жилийн эцэс болохоос өмнө сорьж шалгана.

90О. Хэрэв гүүдвилийг хуваарилсан уг мөнгө бий болгогч нэгжийг бүрдүүлж байгаа хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралтыг тухайн гүүдвилийг агуулж буй нэгжийн хугацаатай ижил хугацаанд сорьж шалгадаг бол тэрхүү гүүдвилийг агуулсан нэгжээс өмнө эдгээр хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг сорьж шалгана. Үүнтэй адилаар, хэрэв гүүдвилийг хуваарилсан уг мөнгө бий болгогч нэгжүүдийн бүлгийг бүрдүүлж байгаа мөнгө бий болгогч нэгжүүдийн үнэ цэнийн бууралтыг тухайн гүүдвилийг агуулж буй нэгжүүдийн бүлгийн хугацаатай ижил хугацаанд сорьж шалгадаг бол тэрхүү гүүдвилийг агуулсан нэгжүүдийн бүлгээс өмнө эдгээр бие даасан нэгжүүдийн үнэ цэнийн бууралтыг сорьж шалгана.

90П. Гүүдвилийг хуваарилсан мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтыг сорьж шалгах үед тухайн гүүдвилийг агуулж буй нэгжийн доторх хөрөнгийн үнэ цэнэ бууралтын шинж тэмдэг илэрч болох юм. Энэ тохиолдолд байгууллага нь эхлээд уг хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг сорьж шалгах ба уг гүүдвилийг агуулж буй мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтыг сорьж шалгахын өмнө тухайн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын аливаа гарзыг хүлээн зөвшөөрнө. Үүнтэй адилаар, гүүдвилийг агуулж буй мөнгө бий болгогч нэгжүүдийн бүлгийн доторх тодорхой нэг мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнэ бууралтын шинж тэмдэг илэрч болох юм. Энэ тохиолдолд байгууллага нь эхлээд уг мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтыг сорьж шалгах ба уг гүүдвилийг

хуваарилах мөнгө бий болгогч нэгжүүдийн бүлгийн үнэ цэнийн бууралтыг сорьж шалгахын өмнө тухайн нэгжийн хувьд үнэ цэнийн бууралтын аливаа гарзыг хүлээн зөвшөөрнө.

90P. Гүүдвилийг хуваарилсан мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүнгийн талаар өмнөх тайлант үед хийсэн, хамгийн сүүлийн нарийвчилсан тооцооллыг хэрэв дараах бүх шалгуур хангагдаж байвал уг нэгжийн тайлант үеийн үнэ цэнэ бууралтын сорилд ашиглаж болох юм:

- (a) Тухайн мөнгө бий болгогч нэгжийг бүрдүүлж буй хөрөнгө, өр төлбөр нь нөхөгдөх дүнгийн хамгийн сүүлийн тооцооллоос хойш мэдэгдэхүйц өөрчлөгдөөгүй;
- (б) Нөхөгдөх дүнгийн хамгийн сүүлийн тооцоолол нь тухайн мөнгө бий болгогч нэгжийн дансны үнээс мэдэгдэхүйц өндөр дүнг харуулсан; ба
- (в) Нөхөгдөх дүнгийн хамгийн сүүлийн тооцооллоос хойш гарч тохиолдсон үйл явдлууд болон өөрчлөгдсөн нөхцөл байдлын шинжилгээнд үндэслэн авч үзэхэд одоогийн нөхөгдөх дүн нь тухайн мөнгө бий болгогч нэгжийн одоогийн дансны үнээс бага болох магадлал маш бага байх.

**Мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтын гарз**

91. Мөнгө бий болгогч нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) нөхөгдөх дүн нь уг нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) дансны үнээс бага байх зөвхөн тийм тохиолдолд мөнгө бий болгогч нэгжийн (гүүдвилийг хуваарилсан мөнгө бий болгогч нэгжүүдийн хамгийн бага бүлгийн) хувьд үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрнө. Тухайн нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) мөнгө бий болгогч хөрөнгүүдийн дансны үнийг бууруулахын тулд үнэ цэнийн бууралтын гарзыг дараах дарааллаар хуваарилна:

- (a) Эхлээд, уг мөнгө бий болгогч нэгжид (нэгжүүдийн бүлэгт) хуваарилсан аливаа гүүдвилийн дансны үнийг бууруулах; ба
- (б) Дараа нь, тухайн нэгж (нэгжүүдийн бүлэг) дэх хөрөнгө тус бүрийн дансны үнэд үндэслэн хувь тэнцүүлсэн байдлаар нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) бусад хөрөнгөд хуваарилан бууруулах.

Дансны үнийн эдгээр бууралтыг бие даасан хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз байдлаар авч үзэх бөгөөд 73-р параграфын дагуу хүлээн зөвшөөрнө.

92. 91-р параграфын дагуу үнэ цэнийн бууралтын гарзыг хуваарилахдаа, байгууллага нь тухайн хөрөнгийн дансны үнийг дараах дүнгүүдийн аль өндрөөс бага болтол бууруулж болохгүй:

- (a) Түүний борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ (хэрэв тодорхойлох боломжтой бол);
- (б) Түүний ашиглалтын үнэ цэнэ (хэрэв тодорхойлох боломжтой бол); ба
- (в) Тэг (0).

**Тухайн хөрөнгөнд хуваарилагдаагүй үлдсэн үнэ цэнийн бууралтын гарзын дүнг уг нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) бусад хөрөнгөнд хувь тэнцүүлэн хуваарилна.**

93. **Мөнгө бий болгодоггүй хөрөнгө нь мөнгө бий болгогч нэгжид хувь нэмрээ оруулдаг тохиолдолд тэрхүү мөнгө бий болгодоггүй хөрөнгийн дансны үнийн хувь тэнцүүлсэн хэсгийг тухайн мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүнгийн тооцооллын өмнөх түүний дансны үнэд хуваарилна. Мөнгө бий болгодоггүй хөрөнгийн дансны үнэ нь УСНББОУС 21-ийн шаардлагуудын дагуу уг тайлангийн өдрөөр тодорхойлсон аливаа үнэ цэнийн бууралтын гарзыг тусгадаг.**
94. Бие даасан хөрөнгийн нөхөгдөх дүнг тодорхойлох боломжгүй тохиолдолд (78-р параграфыг үзнэ үү):
- (a) Хэрэв хөрөнгийн дансны үнэ нь түүний борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ ба 91-93-р параграфт заасан хуваарилалтын горимын үр дүнгийн аль өндрөөс их байвал тухайн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтыг гарзыг хүлээн зөвшөөрнө.
  - (б) Хэрэв холбогдох мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнэ буураагүй бол тухайн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын гарз хүлээн зөвшөөрөхгүй. Хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ нь түүний дансны үнээс бага байсан ч гэсэн үүнийг мөрдөнө.
95. Зарим тохиолдолд мөнгө бий болгодоггүй хөрөнгө нь мөнгө бий болгогч нэгжид хувь нэмрээ оруулдаг. Үнэ цэнийн бууралтын сорилд хамаарах мөнгө бий болгогч нэгж нь мөнгө бий болгодоггүй хөрөнгийг агуулдаг тохиолдолд тэрхүү мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг УСНББОУС 21-ийн шаардлагуудын дагуу сорьж шалгахыг энэхүү Стандартаар шаардсан байдаг. Үнэ цэнийн бууралтын сорилын дараах, уг мөнгө бий болгодоггүй хөрөнгийн дансны үнийн хувь тэнцүүлсэн хэсгийг тэрхүү мөнгө бий болгогч нэгжийн дансны үнэд тусган оруулна. Хувь тэнцүүлсэн хэсэг нь мөнгө бий болгогч нэгжид уг мөнгө бий болгодоггүй хөрөнгийн хувь нэмрээ оруулах үйлчилгээний чадавхийн хэмжээг тусган илэрхийлдэг. Мөнгө бий болгогч нэгжийн аливаа үнэ цэнийн бууралтын гарзыг 92-р параграфт заасан хязгаарлалтанд хамаарах уг мөнгө бий болгогч нэгж дэх мөнгө бий болгодог бүх хөрөнгүүдэд хувь тэнцүүлсэн байдлаар хуваарилна. Мөнгө бий болгодоггүй хөрөнгө нь УСНББОУС 21-ийн дагуу тодорхойлсон үнэ цэнийн бууралтын гарзаас өөр бусад үнэ цэнийн бууралтанд хамаарахгүй.
96. [Хассан]

97. **91-93-р параграф дахь шаардлагуудыг мөрдсөний дараа, мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтын гарзын аливаа үлдсэн дүнгийн хувьд бусад Стандартаар шаардсан бол, зөвхөн тийм тохиолдолд өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.**

**Гүүдвил ба хяналтын бус хувь оролцоо бүхий мөнгө бий болгогч нэгжүүдийн үнэ цэнийн бууралтын сорил**

- 97А. УСНББОУС 40-ийн дагуу нэгтгэгч нь уг нэгдлийн өдрөөр гүүдвилийг доорх (б)-д дурдсан дүнгээс (а)-д дурдсан дүнгийн давж гарсан илүү зөрүүгээр хэмжиж, хүлээн зөвшөөрнө:

(а) дараах зүйлсийн нийлбэр:

- (i) УСНББОУС 40-ийн дагуу хэмжсэн тухайн шилжүүлсэн төлбөр, тэрхүү төлбөр нь ерөнхийдөө уг нэгдлийн өдрөөрх бодит үнэ цэнэ байхыг шаарддаг;
- (ii) УСНББОУС 40-ийн дагуу хэмжсэн, уг худалдан авсан үйл ажиллагаан дахь аливаа хяналтын бус хувь оролцооны дүн; ба
- (iii) Үе шаттайгаар хүрсэн нэгдлийн тохиолдолд, уг худалдан авсан үйл ажиллагааны хувьд нэгтгэгчийн өмнө эзэмшиж байсан өмчийн хувь оролцооны тухайн нэгдлийн өдрөөрх бодит үнэ цэнэ.

- (б) УСНББОУС 40-ийн дагуу хэмжсэн, уг олж эзэмшсэн тодорхойлогдох хөрөнгө ба хариуцсан өр төлбөрийн тухайн нэгдлийн өдрөөрх цэвэр дүн.

*Гүүдвилийн хуваарилалт*

- 97Б. Энэ Стандартын 90А параграф нь тухайн худалдан авсан үйл ажиллагаанд хамаарах бусад хөрөнгө буюу өр төлбөрийг тэрхүү нэгтгэгчийн мөнгө бий болгогч нэгжүүд буюу нэгжүүдийн бүлгүүдэд хуваарилсан эсэхээс үл хамааран уг нэгдлээр хүлээн авсан гүүдвилийг мөнхүү улсын секторын нэгдлийн өргөжилтийн хэмнэлтээс үр өгөөж олохоор хүлээгдэж буй нэгтгэгчийн мөнгө бий болгогч нэгж буюу мөнгө бий болгогч нэгжүүдийн бүлэг нэг бүрд хуваарилахыг шаарддаг. Хяналтын хувь бус хувь эзэмшигч нь өмчлөлийн оролцоогүй тийм мөнгө бий болгогч нэгжид энэхүү улсын секторын нэгдлээс үүссэн зарим өргөжилтийн хэмнэлтийг хуваарилах боломжтой байдаг.

*Үнэ цэнийн бууралтыг сорьж шалгах*

- 97В. Үнэ цэнэ бууралтыг сорьж шалгахдаа мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүнг түүний дансны үнэтэй зэрэгцүүлэн үздэг.
- 97Г. Хэрэв байгууллага нь хяналтын бус хувь оролцоог бодит үнэ цэнээр биш, харин тухайн нэгдлийн худалдан авалтын өдрөөрх уг хяналтанд буй байгууллагын тодорхойлж болох цэвэр хөрөнгө дэх хувь тэнцүүлсэн хувь



оролцоо байдлаар хэмждэг бол энэхүү хяналтын бус хувь оролцоонд хамаарах гүүдвилийг холбогдох мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүнд оруулах боловч хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөхгүй. Иймээс байгууллага нь хяналтын бус хувь оролцоонд хамаарах гүүдвилийг тусган оруулахын тулд тухайн мөнгө бий болгогч нэгжид хуваарилсан гүүдвилийн дансны үнийг нэмж тооцно. Мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнэ буурсан эсэхийг тодорхойлохын тулд энэхүү тохируулсан дансны үнийг дараа нь тухайн нэгжийн нөхөгдөх дүнтэй зэрэгцүүлж үзнэ.

*Үнэ цэнийн бууралтын гарзыг хуваарилах*

97Д. 91-р параграф нь аливаа тодорхойлсон үнэ цэнийн бууралтын гарзыг эхлээд тухайн мөнгө бий болгогч нэгжид хуваарилагдсан гүүдвилийн дансны үнийг бууруулах, дараа нь уг нэгж дэх бусад хөрөнгө тус бүрийн дансны үнэд хувь тэнцүүлэн тэдгээр хөрөнгийн дансны үнийг бууруулах байдлаар хуваарилахыг шаарддаг.

97Е. Хэрэв хяналтанд буй байгууллага эсвэл хяналтын бус хувь оролцоо бүхий уг хяналтанд буй байгууллагын нэг хэсэг нь өөрөө мөнгө бий болгогч нэгж бол үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдлыг хуваарилдагтай ижил сууриар тухайн хяналт тавигч байгууллага болон хяналтын бус хувь оролцоонд хуваарилна.

97Ж. Хэрэв хяналтанд буй байгууллага эсвэл хяналтын бус хувь оролцоо бүхий уг хяналтанд буй байгууллагын нэг хэсэг нь мөнгө бий болгогч арай том нэгжийн нэг хэсэг бол гүүдвилийн үнэ цэнийн бууралтын гарзыг тэрхүү мөнгө бий болгогч нэгжийн хяналтын бус хувь оролцоотой хэсэг ба тийм хувь оролцоогүй хэсгүүдэд хуваарилна. Үнэ цэнийн бууралтын гарзыг мөнгө бий болгогч нэгжийн хэсгүүдэд дараах зүйлд үндэслэн хуваарилна. Үүнд:

(а) Үнэ цэнийн бууралт нь мөнгө бий болгогч нэгж дэх гүүдвилд хамаарах хэмжээгээр тухайн үнэ цэнийн бууралтын өмнөх тэдгээр хэсгүүдийн гүүдвилийн холбогдох дансны үнэд; ба

(б) Үнэ цэнийн бууралт нь мөнгө бий болгогч нэгж дэх тодорхойлж болох хөрөнгүүдэд хамаарах хэмжээгээр тухайн үнэ цэнийн бууралтын өмнөх тэдгээр хэсгүүдийн тодорхойлж болох цэвэр хөрөнгийн холбогдох дансны үнэд. Ийм аливаа ийм үнэ цэнийн бууралтыг уг хэсэг дэх хөрөнгө тус бүрийн дансны үнэд хувь тэнцүүлэн тухайн мөнгө бий болгогч нэгж бүрийн тэдгээр хэсгүүдийн хөрөнгүүдэд хуваарилна.

Хяналтын бус хувь оролцоотой тэдгээр хэсгүүдийн хувьд үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдлыг хуваарилсантай ижил сууриар тухайн хяналт тавигч байгууллага болон хяналтын бус хувь оролцоонд хуваарилна.

97И. Хэрэв хяналтын бус хувь оролцоонд хамаарах үнэ цэнийн бууралтын гарз нь хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээн

зөвшөөрөөгүй гүүдвилтэй (97Г параграфыг үзнэ үү) холбоотой бол тэрхүү үнэ цэнийн бууралтыг гүүдвилийн үнэ цэнийн бууралтын гарз гэж хүлээн зөвшөөрөхгүй. Ийм тохиолдолд зөвхөн хяналт тавигч байгууллагад хуваарилсан гүүдвилтэй холбоотой үнэ цэнийн бууралтын гарзыг гүүдвилийн үнэ цэнийн бууралтын гарз гэж хүлээн зөвшөөрнө.

### **Үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах**

98. Хөрөнгө буюу мөнгө бий болгогч нэгжийн хувьд өмнөх тайлант үеүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах шаардлагуудыг 99-105-р параграфт заасан. Эдгээр шаардлагуудад “хөрөнгө” гэсэн нэр томъёог ашигласан боловч энэ нэр томъёог бие даасан хөрөнгө эсвэл мөнгө бий болгогч нэгжид ижил утгаар хэрэглэнэ. Бие даасан хөрөнгөнд хамаарах нэмэлт шаардлагуудыг 106-109-р параграфт, мөнгө бий болгогч нэгжид хамаарах нэмэлт шаардлагуудыг 110 ба 111-р параграфт, гүүдвилд хамаарах нэмэлт шаардлагуудыг 111А ба 111Б параграфт тус тус заасан.
99. **Гүүдвилээс бусад хөрөнгийн хувьд өмнөх тайлант үеүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарз нь цаашид оршин байгаа больсон буюу буурсан байж болох талаархи ямар нэг шинж тэмдэг байгаа эсэхийг байгууллага нь тайлант үе бүрийн эцэст үнэлнэ. Хэрэв ийм ямар нэг шинж тэмдэг оршин байвал байгууллага нь тухайн хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцоолно.**
100. **Гүүдвилээс бусад хөрөнгийн хувьд өмнөх тайлант үеүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарз нь цаашид оршин байгаа больсон буюу буурсан байж болох талаархи ямар нэг шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлэхдээ, уг байгууллага хамгийн наад зах нь дараах шинж тэмдгийг харгалзан үзнэ:**

#### **Мэдээллийн гадаад эх сурвалж**

- (а) Тухайн хөрөнгийн үнэ цэнэ нь тайлант үеийн туршид мэдэгдэхүйц өссөн;
- (б) Тухайн байгууллагад тааламжтай нөлөөтэй мэдэгдэхүйц өөрчлөлтүүд нь тэрхүү байгууллагын үйл ажиллагаа явуулдаг технологийн, зах зээлийн, эдийн засгийн болон хуулийн орчинд, эсвэл уг хөрөнгийг зориулан зарцуулах зах зээлд энэхүү тайлант үеийн туршид гарч тохиолдсон эсвэл ойрын ирээдүйд гарч тохиолдохоор байх;
- (в) Зах зээлийн хүүний түвшин эсвэл хөрөнгө оруулалтын өгөөжийн зах зээлийн бусад хувь хэмжээ нь тухайн тайлант үеийн туршид буурсан бөгөөд ийм бууралт нь хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг тооцоолоход ашиглах дискаунтын хувь хэмжээнд нөлөөлөх ба уг хөрөнгийн нөхөгдөх дүнг материаллагаар нэмэгдүүлэх магадлалтай байх.

**Мэдээллийн дотоод эх сурвалж**

- (г) Тухайн байгууллагад тааламжтай нөлөөтэй мэдэгдэхүйц өөрчлөлтүүд нь түүний хөрөнгөө ашиглаж байгаа эсвэл ашиглахаар хүлээгдэж буй хэмжээ, арга маягт энэхүү тайлант үеийн туршид гарч тохиолдсон эсвэл ойрын ирээдүйд гарахаар хүлээгдэж байх. Хөрөнгийн гүйцэтгэлийг сайжруулах буюу нэмэгдүүлэх, уг хөрөнгөнд хамааралтай үйл ажиллагаанд бүтцийн өөрчлөлт хийхийн тулд тухайн тайлант үеийн туршид гаргасан өртөг зардал нь ийм өөрчлөлтөнд хамаарна.
- (гА) Хөрөнгийг барьж байгуулах ажил дуусахаас эсвэл ашиглахад бэлэн болгохоос өмнө зогсоосон уг барилгын ажлыг дахин эхлүүлэх шийдвэр.
- (д) Хөрөнгийн эдийн засгийн гүйцэтгэл, үр дүн нь хүлээгдэж байснаас илүү сайн байх эсвэл сайн болно гэдгийг илтгэсэн нотолгоо дотоод тайлагналаас бий болсон байх.
101. 100-р параграфт дурдсан, үнэ цэнийн бууралтын гарзын боломжит багасалтын шинж тэмдгүүд нь үндсэндээ 25-р параграфт дурдсан үнэ цэнийн бууралтын боломжит гарзын шинж тэмдгүүдийн толин тусгал юм.
102. Гүүдвилээс бусад хөрөнгийн хувьд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарз нь цаашид оршин байгаа больсон буюу буурсан байж болох шинж тэмдэг байгаа бол хэдийгээр тухайн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын гарзыг буцаагагүй боловч энэ нь (а) хөрөнгийн ашиглалтын үлдсэн хугацаа, (б) элэгдлийн (хорогдуулгын) арга, (в) хөрөнгийн үлдэх өртгийг дахин хянан үзэж, тухайн хөрөнгөнд хамаарах Стандартын дагуу тохируулах шаардлагатай гэдгийг илэрхийлж болох юм.
103. **Хамгийн сүүлд үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрснөөс хойш тухайн хөрөнгийн нөхөгдөх дүнг тодорхойлоход ашигласан тооцоололд өөрчлөлт орсон зөвхөн тийм тохиолдолд гүүдвилээс бусад хөрөнгийн хувьд өмнөх тайлант үеүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаана. Ингэж буцаахдаа 106-р параграфт зааснаас бусад тохиолдолд тухайн хөрөнгийн дансны үнийг түүний нөхөгдөх дүн хүртэл өсгөнө. Ийм өсөлт нь үнэ цэнийн бууралтын гарзын буцаалт юм.**
104. Үнэ цэнийн бууралтын гарзын буцаалт нь байгууллага тухайн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын гарзыг хамгийн сүүлд хүлээн зөвшөөрсөн өдрөөс хойш хөрөнгийн ашиглалт буюу борлуулалтын аль нэгээр түүний тооцоолсон үйлчилгээний чадавхид гарсан өсөлтийг илэрхийлнэ. Байгууллага нь тооцоолсон үйлчилгээний чадавхийн өсөлтийн шалтгаан болж буй уг тооцооллын өөрчлөлтийг тодорхойлох шаардлагатай байдаг. Тооцооллын өөрчлөлтийн жишээнд дараах зүйлс хамаарна:

- (а) Нөхөгдөх дүнгийн суурьт орсон өөрчлөлт (өөрөөр хэлбэл, нөхөгдөх дүн нь борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэд эсвэл ашиглалтын үнэ цэнэд үндэслэх эсэх);
  - (б) Хэрэв нөхөгдөх дүн нь ашиглалтын үнэ цэнэд үндэслэсэн бол тооцоолсон ирээдүйн мөнгөн гүйлгээний дүн буюу хугацаанд эсвэл дискаунтын хувьд орсон өөрчлөлт; буюу
  - (в) Хэрэв нөхөгдөх дүн нь борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэд үндэслэсэн бол борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн бүрэлдэхүүн хэсгүүдийн тооцоололд орсон өөрчлөлт.
105. Ирээдүйн мөнгөн орлогын гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ нь хугацаа ойртохын хирээр өсдөг тул хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ нь зүгээр л тухайн хөрөнгийн дансны үнээс илүү болж болох юм. Гэхдээ уг хөрөнгийн үйлчилгээний чадавхи өсөхгүй. Иймээс хэдийгээр хөрөнгийн нөхөгдөх дүн нь түүний дансны үнээс өндөр болсон ч гэсэн зөвхөн цаг хугацаа өнгөрөхийн хирээр (заримдаа үүнийг дискаунтын “задралт” гэж нэрлэдэг) үнэ цэнийн бууралтын гарзыг буцаахгүй.

#### **Бие даасан хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах**

106. **Үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтанд хамаарах гүүдвилээс бусад хөрөнгийн нэмэгдсэн дансны үнэ нь хэрэв тухайн хөрөнгийн хувьд өмнөх жилүүдэд үнэ цэнийн бууралтын гарз хүлээн зөвшөөрөөгүй байсан бол тодорхойлогдох байсан дансны үнээс (элэгдэл буюу хорогдуулгыг хассан цэвэр дүнгээс) хэтрэх ёсгүй.**
107. Хэрэв тухайн хөрөнгийн хувьд өмнөх жилүүдэд үнэ цэнийн бууралтын гарз хүлээн зөвшөөрөөгүй байсан бол тодорхойлогдох байсан дансны үнээс (элэгдэл буюу хорогдуулгыг хассан цэвэр дүнгээс) давсан, гүүдвилээс бусад хөрөнгийн дансны үнийн аливаа өсөлт нь дахин үнэлгээ юм. Ийм дахин үнэлгээг тайлагнахдаа байгууллага нь тухайн хөрөнгөнд хамаарах холбогдох Стандартыг мөрдөнө.
108. **Тухайн хөрөнгийг бусад Стандартын (жишээлбэл, УСНББОУС 17 ба УСНББОУС 31-д заасан дахин үнэлгээний загвар) дагуу түүний дахин үнэлсэн дүнгээр тайлагнаснаас бусад тохиолдолд гүүдвилээс бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтыг ашиг, алдагдалд шууд хүлээн зөвшөөрнө. Дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзын аливаа буцаалтыг тэрхүү бусад Стандартын дагуу дахин үнэлгээний нэмэгдэлтэй адилаар авч үзнэ.**
- 108A. Дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтыг дахин үнэлгээний нэмэгдэлд шууд хүлээн зөвшөөрөх ба тухайн хөрөнгийн ангийн хувьд дахин үнэлгээний нэмэгдлийг өсгөнө. Гэвч тухайн дахин үнэлсэн хөрөнгийн ангийн хувьд үнэ цэнийн бууралтын гарзыг өмнө нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн тэр хэмжээгээр уг үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтыг мөн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

109. Үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтыг хүлээн зөвшөөрсний дараа, үлдэх өртгийг (хэрэв байгаа бол) нь хассан уг хөрөнгийн хянан засварласан дансны үнийг түүний үлдэх ашиглалтын хугацаанд системчилсэн сууриар хуваарилахын тулд тухайн хөрөнгийн элэгдлийг (хорогдуулгыг) ирээдүйн тайлант үеүдэд тохируулна.

#### **Мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах**

110. Мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтыг тухайн нэгж дэх гүүдвилээс бусад хөрөнгүүдэд тэдгээр хөрөнгийн дансны үнээр хувь тэнцүүлэн хуваарилна. Дансны үнийн энэхүү өсөлтийг уг бие даасан хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралтын гарзын буцаалт гэж үзэх бөгөөд 108-р параграфын дагуу хүлээн зөвшөөрнө. Мөнгө бий болгогч нэгжид үйлчилгээний чадавхийн хувь нэмэр оруулдаг мөнгө бий болгодоггүй хөрөнгөнд ийм буцаалтын дүнгийн аливаа нэг хэсгийг хуваарилахгүй.
111. Мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнэ бууралтын гарзын буцаалтыг 110-р параграфын дагуу хуваарилахдаа тухайн хөрөнгийн дансны үнийг дараах дүнгүүдийн аль багаас илүү болтол өсгөхгүй:
- (а) Түүний нөхөгдөх дүн (хэрэв тодорхойлох боломжтой бол); ба
  - (б) Хэрэв уг хөрөнгийн хувьд өмнөх тайлант үеүдэд үнэ цэнийн бууралтын гарз хүлээн зөвшөөрөөгүй байсан бол тодорхойлогдох байсан дансны үнэ (элэгдэл буюу хорогдуулгыг хассан цэвэр дүн).

Тухайн хөрөнгөнд хуваарилагдаагүй үлдсэн үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтын дүнг уг нэгжийн гүүдвилээс бусад хөрөнгүүдэд хувь тэнцүүлэн хуваарилна.

#### **Гүүдвилийн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах**

- 111А. Гүүдвилийн хувьд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг дараагийн тайлант үед буцаахгүй.
- 111Б. УСНББОУС 31 нь дотооддоо бий болгосон гүүдвилийг хүлээн зөвшөөрөхийг хориглодог. Тухайн гүүдвилийн хувьд үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрсний дараах тайлант үеүдэд гүүдвилийн нөхөгдөх дүнд гарсан аливаа өсөлт нь уг олж эзэмшсэн гүүдвилийн хувьд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзын буцаалт биш, харин дотооддоо бий болгосон гүүдвилийн өсөлт байх магадлалтай байдаг.

#### **Хөрөнгийг дахин ангилал**

112. Хөрөнгийг мөнгө бий болгогч хөрөнгөөс мөнгө бий болгодоггүй хөрөнгө болгох, эсвэл мөнгө бий болгодоггүй хөрөнгөөс мөнгө бий болгогч хөрөнгө болгох дахин ангилал нь тохиромжтой гэсэн тодорхой нотолгоо байгаа зөвхөн тийм тохиолдолд дахин ангиллыг

**хийнэ. Дахин ангилал нь өөрөө үнэ цэнийн бууралтын сорил хийх эсвэл үнэ цэнийн бууралтын гарзыг буцаахад заавал хүргэх албагүй юм. Ийм дахин ангилал хийсний дараагийн тайлант үед уг байгууллага нь хамгийн наад зах нь 25-р параграфт жагсаан харуулсан шинж тэмдгүүдийг харгалзан үзнэ.**

113. Улсын секторын байгууллагууд нь мөнгө бий болгогч хөрөнгийг мөнгө бий болгодоггүй хөрөнгө болгон дахин ангилах нь тохиромжтой гэж шийдвэрлэж болох нөхцөл байдлууд байдаг. Жишээлбэл; бохир ус зайлуулах байгууламжийг анх аж үйлдвэрийн зориулалттай хөрөнгийн үйлдвэрлэлийн бохир усыг төлбөртэйгээр зайлуулахын тулд барьсан бөгөөд түүний илүүдэл хүчин чадлыг нийтийн аж ахуйн албаны бохир усыг үнэ төлбөргүй зайлуулах зорилгоор ашигладаг. Аж үйлдвэрийн зориулалттай үл хөрөнгийн үйл ажиллагааг саяхан зогсоосон бөгөөд тухайн байгууламжийг цаашид нийтийн аж ахуйн албаны зорилгоор ашиглахын тулд сайжруулан хөгжүүлнэ. Аж үйлдвэрийн зориулалттай үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааг бүрэн зогсоосон тул улсын секторын байгууллага нь уг бохир ус зайлуулах байгууламжийг мөнгө бий болгодоггүй хөрөнгө гэж дахин ангилахаар шийдвэрлэжээ.

## **Тодруулга**

114. **Байгууллага нь мөнгө бий болгогч хөрөнгийг мөнгө бий болгодоггүй хөрөнгөөс ялган зааглахын тулд өөрийн боловсруулсан шалгуураа тодруулна.**
115. **Байгууллага нь хөрөнгийн анги тус бүрийн хувьд дараах зүйлсийг тодруулна:**
- (а) **Тухайн тайлант үеийн туршид ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнэ бууралтын гарзын дүн ба тэдгээр үнэ цэнэ бууралтын гарзыг тусгасан санхүүгийн үр дүнгийн тайлангийн мөрийн зүйлс.**
  - (б) **Тухайн тайлант үеийн туршид ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнэ бууралтын гарзын буцаалтын дүн ба тэдгээр үнэ цэнэ бууралтын гарзыг буцаасан санхүүгийн үр дүнгийн тайлангийн мөрийн зүйлс.**
  - (в) **Тухайн тайлант үеийн туршид дахин үнэлгээний нэмэгдэлд хүлээн зөвшөөрсөн, дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнэ бууралтын гарзын дүн.**
  - (г) **Тухайн тайлант үеийн туршид дахин үнэлгээний нэмэгдэлд хүлээн зөвшөөрсөн, дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнэ бууралтын гарзын буцаалтын дүн.**
116. Зарим тохиолдолд хөрөнгийг эзэмшиж буй үндсэн зорилго нь арилжааны үр өгөөж бий болгох эсэх нь тодорхой бус байж болох юм. Ийм тохиолдолд энэ Стандартыг эсвэл УСНББОУС 21-ийг мөрдөх эсэхийг тодорхойлохдоо шүүн тунгаалт хийх шаардлагатай. Мөнгө бий болгогч

хөрөнгө болон мөнгө бий болгодоггүй хөрөнгийг ялган зааглахад ашигласан шалгуурын талаар тодруулга хийхийг 114-р параграфтаар шаардсан байдаг.

117. Хөрөнгийн анги гэдэг нь байгууллагын үйл ажиллагааны хувьд ижил төсөөтэй шинж төрөл буюу чиг үүрэг бүхий хөрөнгүүдийн бүлэглэл бөгөөд тухайн санхүүгийн тайланд толилуулах зорилгоор түүнийг ганц зүйл байдлаар харуулдаг.
118. 115-р параграфт шаардсан мэдээллийг тухайн хөрөнгийн ангийн хувьд тодруулах бусад мэдээллийн хамт толилуулж болно. Жишээлбэл; УСНББОУС 17-гоор шаардсанчлан, тайлант үеийн эхэн ба эцэс дэх үндсэн хөрөнгийн дансны үнийн тохируулгын тайланд энэхүү мэдээллийг оруулж болох юм.
119. **УСНББОУС 18, Сегментийн Тайлагнал-ын дагуу сегментийн мэдээллийг тайлагнаж буй байгууллага нь өөрийн тайлагналын хэлбэр загварт үндэслэн тайлагнасан сегмент тус бүрийн хувьд дараах зүйлсийг тодруулна:**
- (a) Тухайн тайлант үеийн туршид ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзын дүн.
  - (б) Тухайн тайлант үеийн туршид ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтын дүн.
120. **Байгууллага нь мөнгө бий болгогч хөрөнгө (үүн дотроо, гүүдвил) буюу мөнгө бий болгогч нэгжийн хувьд тухайн тайлант үеийн туршид хүлээн зөвшөөрсөн эсвэл буцаасан материаллаг үнэ цэнийн бууралтын гарз тус бүрээр дараах зүйлсийг тодруулна:**
- (a) Үнэ цэнэ бууралтын гарзын хүлээн зөвшөөрөлт эсвэл буцаалтанд хүргэсэн үйл явдлууд болон нөхцөл байдлууд;
  - (б) Хүлээн зөвшөөрсөн эсвэл буцаасан үнэ цэнэ бууралтын гарзын дүн;
  - (в) **Мөнгө бий болгогч хөрөнгийн хувьд:**
    - (i) Хөрөнгийн шинж төрөл; ба
    - (ii) Хэрэв байгууллага нь УСНББОУС 18-ын дагуу сегментийн мэдээллийг тайлагнадаг бол түүний тайлагналын хэлбэр загварт үндэслэсэн бөгөөд тухайн хөрөнгийн харъяалагдах уг тайлагнасан сегмент.
  - (г) **Мөнгө бий болгогч нэгжийн хувьд:**
    - (i) Мөнгө бий болгогч нэгжийн тодорхойлолт (энэ нь бүтээгдэхүүний төрөл, үйлдвэр, бизнесийн үйл ажиллагаа, газарзүйн бүс нутаг эсвэл тайлагнасан сегмент эсэх гэх мэт);

- (ii) **Хөрөнгийн ангиар, түүнчлэн хэрэв байгууллага нь УСНББОУС 18-ын дагуу сегментийн мэдээллийг тайлагнадаг бол тухайн байгууллагын тайлагналын хэлбэр загварт үндэслэсэн, уг тайлагнасан сегментээр хүлээн зөвшөөрсөн эсвэл буцаасан үнэ цэнэ бууралтын гарзын дүн; ба**
  - (iii) **Мөнгө бий болгогч нэгжийг тодорхойлохын тулд хийгдэх хөрөнгийн нэгтгэн нийлүүлэлт нь тухайн мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүнгийн өмнөх тооцооллоос (хэрэв байгаа бол) хойш өөрчлөгдсөн бол хөрөнгүүдийг нэгтгэн нийлүүлэх одоогийн болон өмнөх арга замуудын тайлбар тодорхойлолт, түүнчлэн мөнгө бий болгогч нэгжийг тодорхойлох арга замыг өөрчилсөн шалтгаан.**
  - (д) **Тухайн хөрөнгийн (мөнгө бий болгогч нэгжийн) нөхөгдөх дүн нь түүний борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ эсвэл ашиглалтын үнэ цэнэ эсэх.**
  - (е) **Хэрэв нөхөгдөх дүн нь борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ бол уг борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийг тодорхойлоход ашигласан суурь (идэвхитэй зах зээлийн үнийг лавлагаа болгосноор бодит үнэ цэнийг тодорхойлсон эсэх гэх мэт); ба**
  - (ж) **Хэрэв нөхөгдөх дүн нь ашиглалтын үнэ цэнэ бол уг ашиглалтын үнэ цэнийн одоогийн болон өмнөх тооцоололд (хэрэв байгаа бол) ашигласан дискаунтын хувь.**
121. **120-р параграфын дагуу мэдээллийг тодруулаагүй тухайн тайлант үеийн туршид хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзын нэгтгэн нийлүүлсэн дүн ба үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтын нэгтгэн нийлүүлсэн дүнгийн хувьд байгууллага нь дараах мэдээллийг тодруулна:**
- (а) **Үнэ цэнийн бууралтын гарзаар нөлөө үзүүлсэн хөрөнгийн гол ангиуд ба үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтаар нөлөө үзүүлсэн хөрөнгийн гол ангиуд.**
  - (б) **Эдгээр үнэ цэнийн бууралтын гарз ба үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтыг хүлээн зөвшөөрөхөд хүргэсэн гол үйл явдлууд болон нөхцөл байдлууд.**
122. **Байгууллага нь тухайн тайлант үеийн туршид хөрөнгийн нөхөгдөх дүнг тодорхойлохын тулд ашигласан таамаглалуудаа тодруулахыг дэмжинэ. Гэвч тухайн мөнгө бий болгогч нэгжийн дансны үнэд гүүдвил эсвэл тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгө багтсан тохиолдолд уг мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүнг хэмжихдээ ашигласан тооцооллын талаархи мэдээллийг тодруулахыг тэрхүү байгууллагаас 123-р параграфтаар шаардсан байдаг.**



- 122А. 90Д параграфт заасанчлан, тухайн тайлант үеийн туршид улсын секторын нэгдлээр олж эзэмшсэн гүүдвилийн аливаа нэг хэсгийг уг тайлант үеийн эцэст мөнгө бий болгогч нэгжид (нэгжүүдийн бүлэгт) хуваарилаагүй байвал тэрхүү хуваарилагдаагүй гүүдвилийн дүнг яагаад ингэж хуваарилаагүй үлдсэн шалтгааны хамт тодруулна.

Тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийг агуулсан мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүнг хэмжихэд ашигласан тооцооллын тодруулга

123. Тухайн мөнгө бий болгогч нэгжид (нэгжүүдийн бүлэгт) хуваарилсан гүүдвил буюу тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн дансны үнэ нь уг байгууллагын гүүдвил буюу тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн нийт дансны үнэтэй харьцуулахад мэдэгдэхүйц их байх тохиолдолд байгууллага нь тэдгээр мөнгө бий болгогч нэгж (нэгжүүдийн бүлэг) тус бүрийн хувьд доорх (а)-(е)-д шаардсан мэдээллийг тодруулна:

- (а) Тухайн мөнгө бий болгогч нэгжид (нэгжүүдийн бүлэгт) хуваарилсан гүүдвилийн дансны үнэ;
- (б) Тухайн мөнгө бий болгогч нэгжид (нэгжүүдийн бүлэгт) хуваарилсан тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн дансны үнэ;
- (в) Мөнгө бий болгогч нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) нөхөгдөх дүнг тодорхойлсон суурь (өөрөөр хэлбэл, ашиглалтын үнэ цэнэ эсвэл борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ).
- (г) Хэрэв мөнгө бий болгогч нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) нөхөгдөх дүн нь ашиглалтын үнэ цэнэд үндэслэсэн бол:
  - (i) Хамгийн сүүлийн төсөв/прогнозын хамрах тухайн тайлант үеийн хувьд удирдлага нь өөрийн мөнгөн гүйлгээний төсөвлөлтийн үндэслэл болгосон гол таамаглал нэг бүрийн тайлбар тодорхойлолт. Гол таамаглал гэдэг нь тухайн мөнгө бий болгогч нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) нөхөгдөх дүн хамгийн их хамааралтай, мэдрэмтгий байх тийм таамаглалууд юм;
  - (ii) Гол таамаглал тус бүрд хамааруулан хуваарилсан үнэ цэнийг тодорхойлох удирдлагын арга хандлагын тайлбар тодорхойлолт. Эдгээр үнэ цэнэ нь өмнөх туршлагыг тусгасан эсвэл зохих мэдээллийн гадаад эх сурвалжтай нийцэн тохирч байгаа эсэх, хэрэв тийм биш бол өмнөх туршлага эсвэл мэдээллийн гадаад эх сурвалжаас яагаад, хэр их өөр байгаа эсэх;
  - (iii) Удирдлагын баталсан санхүүгийн төсөв/прогнозод үндэслэн мөнгөн гүйлгээг удирдлага төсөвлөн тооцсон тайлант хугацаа, тухайн мөнгө бий болгогч нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) хувьд таван жилээс урт хугацааг

ашигласан тохиолдолд яагаад ийм урт хугацаа тохиромжтой гэдгийг зөвтгөн баталсан тайлбар;

- (iv) Хамгийн сүүлийн төсөв/прогнозод хамаарах тайлант үеэс хойшхи хугацааны мөнгөн гүйлгээний төсөвлөлтөнд экстраполяци (төсөөлөн тооцолт) хийхдээ ашигласан өсөлтийн хувь ба уг байгууллагын үйлдвэрлэдэг бүтээгдэхүүн, түүний үйл ажиллагаагаа явуулдаг салбар, улс буюу улс орнууд, эсвэл тухайн мөнгө бий болгогч нэгжийг (нэгжүүдийн бүлгийг) ашигладаг зах зээлийн урт хугацааны өсөлтийн дундаж хувиас давсан аливаа өсөлтийн хувийг ашиглах үндэслэл;
  - (v) Мөнгөн гүйлгээний төсөвлөлтөнд ашигласан дискаунтын хувь;
- (д) Хэрэв мөнгө бий болгогч нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) нөхөгдөх дүн нь борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэд үндэслэсэн бол уг борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийг хэмжихдээ ашигласан үнэлгээний арга зүй. Хэрэв борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийг тухайн нэгжийн ажиглаж болох зах зээлийн үнийг ашиглан хэмжээгүй бол дараах мэдээллийг бас тодруулна:
- (i) Удирдлага нь борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийг тодорхойлохдоо үндэслэл болгосон гол таамаглал нэг бүрийн тайлбар тодорхойлолт. Гол таамаглал гэдэг нь тухайн мөнгө бий болгогч нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) нөхөгдөх дүн хамгийн их хамааралтай, мэдрэмтгий байх тийм таамаглалууд юм.
  - (ii) Гол таамаглал тус бүрд хамааруулан хуваарилсан үнэ цэнийг (эсвэл үнэ цэнүүдийг) тодорхойлох удирдлагын арга хандлагын тайлбар тодорхойлолт. Эдгээр үнэ цэнэ нь өмнөх туршлагыг тусгасан эсвэл зохих мэдээллийн гадаад эх сурвалжтай нийцэн тохирч байгаа эсэх, хэрэв тийм биш бол өмнөх туршлага эсвэл мэдээллийн гадаад эх сурвалжаас яагаад, хэр их өөр байгаа эсэх.
- Хэрэв борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийг дискаунтчилсан мөнгөн гүйлгээний төсөвлөлт ашиглан хэмжсэн бол байгууллага нь дараах мэдээллийг бас тодруулна:
- (iii) Удирдлага нь мөнгөн гүйлгээг төсөвлөсөн тайлант хугацаа;
  - (iv) Мөнгөн гүйлгээний төсөвлөлтөнд экстраполяци хийхдээ ашигласан өсөлтийн хувь;
  - (v) Мөнгөн гүйлгээний төсөвлөлтөнд ашигласан дискаунтын хувь.

- (e) Хэрэв мөнгө бий болгогч нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) нөхөгдөх дүнг тодорхойлохдоо удирдлагын үндэслэл болгосон гол таамаглалд гарах ул үндэслэлтэйгээр боломжит өөрчлөлт нь уг нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) дансны үнэ түүний нөхөгдөх дүнгээсээ хэтэрч, илүү гарахад хүргэж байвал:
- (i) Тухайн мөнгө бий болгогч нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) нөхөгдөх дүн нь түүний дансны үнээс хэтэрч, давсан дүн;
  - (ii) Гол таамаглал тус бүрд хамааруулан хуваарилсан үнэ цэнэ;
  - (iii) Мөнгө бий болгогч нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) нөхөгдөх дүн нь түүний дансны үнэтэй тэнцүү байхын тулд нөхөгдөх дүнг хэмжихэд ашигласан бусад хувьсагчдад уг өөрчлөлтийн үзүүлэх цаашдын аливаа үр нөлөөг нэгтгэн тооцсоны дараа тэрхүү гол таамаглалд хамааруулан хуваарилах үнэ цэнийн дүн өөрчлөгдөх ёстой.

124. Хэрэв гүүдвил буюу тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгүүдийн бүх буюу зарим дансны үнийг мөнгө бий болгогч олон нэгжүүдэд (нэгжүүдийн бүлгүүдэд) дамжуулан хуваарилсан ба нэгж (нэгжүүдийн бүлэг) бүрд ингэж хуваарилсан дүн нь тухайн байгууллагын гүүдвил буюу тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн нийт дансны үнэтэй харьцуулахад мэдэгдэхүйц их биш бол тэдгээр нэгжүүдэд (нэгжүүдийн бүлгүүдэд) хуваарилсан гүүдвил буюу тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн нийт дансны үнийн хамтаар энэ тухай тодруулга хийнэ. Түүнчлэн, мөнгө бий болгогч нэгжүүдэд (нэгжүүдийн бүлгүүдэд) хуваарилсан гүүдвил буюу тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн нийт дансны үнэд болон уг гол таамаглалуудад үндэслэсэн тэдгээр нэгжүүдийн (нэгжүүдийн бүлгүүдийн) нөхөгдөх дүн нь уг байгууллагын гүүдвил буюу тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн нийт дансны үнэтэй харьцуулахад мэдэгдэхүйц их байвал байгууллага нь энэ тухай доорх зүйлсийн хамт тодруулна:

- (a) Тэдгээр мөнгө бий болгогч нэгжүүдэд (нэгжүүдийн бүлгүүдэд) хуваарилсан гүүдвиллийн нийт дансны үнэ;
- (б) Тэдгээр мөнгө бий болгогч нэгжүүдэд (нэгжүүдийн бүлгүүдэд) хуваарилсан тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн нийт дансны үнэ;
- (в) Гол таамаглалуудын тухай тайлбар тодорхойлолт;
- (г) Гол таамаглалуудад хамааруулан хуваарилсан үнэ цэнийг тодорхойлох удирдлагын арга хандлагын тайлбар тодорхойлолт. Эдгээр үнэ цэнэ нь өмнөх туршлагыг тусгасан эсвэл зохих мэдээллийн гадаад эх сурвалжтай нийцэн тохирч байгаа эсэх, хэрэв тийм биш бол өмнөх туршлага эсвэл

мэдээллийн гадаад эх сурвалжаас яагаад, хэр их өөр байгаа эсэх;

- (д) Хэрэв гол таамаглалд гарах ул үндэслэлтэйгээр боломжит өөрчлөлт нь уг мөнгө бий болгогч нэгжүүдийн (нэгжүүдийн бүлгүүдийн) дансны үнэ тэдгээрийн нөхөгдөх дүнгээсээ хэтэрч, илүү гарахад хүргэж байвал:
- (i) Тухайн мөнгө бий болгогч нэгжүүдийн (нэгжүүдийн бүлгүүдийн) нийт нөхөгдөх дүн нь тэдгээрийн дансны үнээс хэтэрч, давсан дүн;
  - (ii) Гол таамаглал тус бүрд хамааруулан хуваарилсан үнэ цэнэ;
  - (iii) Мөнгө бий болгогч нэгжүүдийн (нэгжүүдийн бүлгүүдийн) нийт нөхөгдөх дүн нь тэдгээрийн нийт дансны үнэтэй тэнцүү байхын тулд нөхөгдөх дүнг хэмжихэд ашигласан бусад хувьсагчдад уг өөрчлөлтийн үзүүлэх цаашдын аливаа үр нөлөөг нэгтгэн тооцсоны дараа тэрхүү гол таамаглалд хамааруулан хуваарилах үнэ цэнийн дүн өөрчлөгдөх ёстой.

125. Мөнгө бий болгогч нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) нөхөгдөх дүнгийн хувьд өмнөх тайлант үед хийсэн, хамгийн сүүлийн дэлгэрэнгүй тооцоолол нь хэрэв тусгайлан заасан шалгуурыг хангаж байвал 37 буюу 90P параграфын дагуу тэдгээрийг дараагийн тайлант үед шилжүүлж, тухайн тайлант үед уг нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) үнэ цэнийн бууралтыг сориход ашиглаж болно. Ингэж шилжүүлэн ашиглах тохиолдолд 123 ба 124-р параграфуудад шаардсан тодруулгад тусгасан уг нэгжийн (нэгжүүдийн бүлгийн) талаархи мэдээлэл нь нөхөгдөх дүнгийн хувьд хийж, өмнөх тайлант үеэс шилжүүлэн авсан тооцоололтой холбоотой байна.

## Хүчин төгөлдөр болох хугацаа

126. Байгууллага нь энэхүү Стандартыг 2009 оны 4 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2009 оны 4 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.

126A. 2010 оны 01 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Сайжруулалтууд*-аар 25 ба 100-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2011 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Хэрэв байгууллага нь УСНББОУС 16-гийн 12, 13, 29, 40, 57, 59, 62, 62A, 62B, 63, 66, 101A параграфуудын нэмэлт өөрчлөлтүүдийг мөн тэрхүү өмнөх хугацаанаас эхлэн дагаж мөрдсөн бол энэ Стандартыг дээр дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2011

оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.

- 126Б. 2010 оны 11 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Сайжруулалтууд*-аар 123-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2011 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2011 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 126В. УСНББОУС 31-ийн үр дүнд 2(и) параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2011 оны 4 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Хэрэв байгууллага нь 2011 оны 4 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед УСНББОУС 31-ийг мөрдсөн бол уг нэмэлт өөрчлөлтийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.
- 126Г. 2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-ийн үр дүнд 127-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед УСНББОУС 33-ыг мөрдсөн бол уг нэмэлт өөрчлөлтийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.
- 126Д. 2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан* ба УСНББОУС 37, *Хамтын Хэлэлцээр*-ийн үр дүнд 12-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь УСНББОУС 35 ба УСНББОУС 37-г мөрдсөн үеэс уг нэмэлт өөрчлөлтийг дагаж мөрдөнө.
- 126Е. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд*-аар 2 ба 8-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 126Ж. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 3, 4-р параграфуудыг хасаж, 5, 18-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр

нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.

- 126И. *Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт* (УСНББОУС 21 ба 26-гийн нэмэлт өөрчлөлтүүд)-аар 2, 73, 108, 115, 124-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулж, 6, 11-р параграфуудыг хассан ба 73А, 108А параграфуудыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 126К. 2016 оны 7 дугаар сард гаргасан УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийн үр дүнд 2-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 39-ийг мөрдөнө.
- 126Л. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийн үр дүнд 2, 23, 71, 76, 88, 91, 92, 98-100, 102, 103, 106-108, 110, 111, 120, 122, 123-125-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулж, 18А, 20А, 90А-90Р, 97А-97И, 111А, 111Б, 122А параграфуудыг шинээр нэмсэн ба 7, 96-р параграфуудыг хассан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.
127. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт* (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

## Хавсралт А

### Мөрдөх заавар удирдамж

*Энэ Хавсралт нь УСНББОУС 26-гийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.*

### Ашиглалтын үнэ цэнийг хэмжихэд өнөөгийн үнэ цэнийн арга зүйг ашиглах

*Заавар удирдамжинд “хөрөнгө” гэсэн нэр томъёог ашигласан боловч мөнгө бий болгогч нэгжийг бүрдүүлж буй хөрөнгүүдийн бүлэгт үүнийг мөн адил хэрэглэнэ.*

*Өнөөгийн үнэ цэнийн хэмжилтийн бүрэлдэхүүн хэсгүүд*

МЗУ1. Дараах зүйлс нь мөнгө бий болгогч хөрөнгүүдийн хоорондох эдийн засгийн ялгаатай талыг хамтран илэрхийлнэ:

- (а) Тухайн хөрөнгөөс байгууллагын олж авахаар хүлээж буй ирээдүйн мөнгөн гүйлгээний буюу илүү нарийн цогц нөхцөл байдалд, хэд хэдэн ирээдүйн мөнгөн гүйлгээний тооцоолол;
- (б) Тэдгээр ирээдүйн мөнгөн гүйлгээний дүн буюу хугацаанд гарах боломжит хэлбэлзэл өөрчлөлтүүдийн талаархи хүлээлт;
- (в) Эрсдэлгүй хүүний одоогийн зах зээлийн хувь хэмжээгээр илэрхийлэгдэх мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ;
- (г) Тухайн хөрөнгийн угийн тодорхойгүй байдалд хамаарах үнэ;
- (д) Зах зээлд оролцогчид нь уг хөрөнгөөс тухайн байгууллагын олохоор хүлээж буй ирээдүйн мөнгөн гүйлгээг үнэлэн тооцохдоо харгалзан тусгах, зарим үед тодорхойлох боломжгүй бусад хүчин зүйлс (төлбөрийн чадваргүй байдал гэх мэт).

МЗУ2. Өнөөгийн үнэ цэнийг тооцоолох хоёр хандлагыг энэхүү хавсралт харьцуулан харуулсан бөгөөд тухайн нөхцөл байдлаас хамааран хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг тооцоолохдоо аль нэгийг ашиглаж болох юм. “Уламжлалт” хандлагын дагуу дээрх МЗУ1 параграфын (б)-(д)-д дурдсан хүчин зүйлсийн тохируулгыг дискаунтын хувьд тусгадаг. Харин “хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний” хандлагын дагуу дээрх (б), (г), (д)-д дурдсан хүчин зүйлс нь эрсдлээр тохируулсан хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг гаргах тохируулга хийхэд хүргэдэг. Байгууллага нь ирээдүйн мөнгөн гүйлгээний дүн буюу хугацаанд гарах боломжит хэлбэлзэл өөрчлөлтүүдийн талаархи өөрийн хүлээлтийг тусгахын тулд аль ч аргыг хэрэглэсэн байлаа гэхэд уг үр дүн нь ирээдүйн мөнгөн гүйлгээний хүлээгдэж буй өнөөгийн үнэ цэнийг, өөрөөр хэлбэл боломжит бүх үр дагаврын жинэлсэн дундажийг илэрхийлнэ.

*Ерөнхий зарчмууд*

МЗУ3. Ирээдүйн мөнгөн гүйлгээ болон хүүний түвшинг тооцоолохдоо ашиглах арга зүй нь тухайн авч үзэж буй хөрөнгийн орчны нөхцөл байдлаас

## МӨНГӨ БИЙ БОЛГОГЧ ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

хамааран тохиолдол бүрд өөр өөр байдаг. Гэхдээ хөрөнгийг хэмжихдээ өнөөгийн үнэ цэнийн арга зүйг хэрэглэх аливаа тохиолдлыг дараах ерөнхий зарчмуудаар удирдан зохицуулна:

- (а) Мөнгөн гүйлгээг дискаунтчлахад ашиглах хүүний түвшин нь тухайн тооцоолсон мөнгөн гүйлгээний хувьд угаасаа хийх таамаглалтай нийцэн тохирох тийм таамаглалуудыг тусгасан байвал зохино. Тэгэхгүй бол зарим таамаглалын үр нөлөөг давхардуулан тооцоолох эсвэл заримыг орхигдуулахад хүргэх юм. Жишээлбэл; зээлийн авлагын гэрээт мөнгөн гүйлгээний хувьд 12 хувийн дискаунтын түвшинг ашигладаг байж болох юм. Энэхүү түвшин нь тухайн шинж чанар бүхий зээлийн хувьд ирээдүйн төлбөрийн үл биелүүлэлтийн талаархи хүлээлтийг тусгасан байна. Эдгээр мөнгөн гүйлгээ нь ирээдүйн төлбөрийн үл биелүүлэлтийн талаархи хүлээлтийг нэгэнт тусгасан тул хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг дискаунтчлахдаа тэрхүү 12 хувийг түвшинг ашиглахгүй юм.
- (б) Тооцоолсон мөнгөн гүйлгээ болон дискаунтын хувь нь тухайн авч үзэж буй хөрөнгөтэй холбоогүй хүчин зүйлс ба аль нэг талыг барьсан хазайлт хэлбийлтээс ангид байх ёстой. Жишээлбэл; хөрөнгийн ирээдүйн ашигт ажиллагааг илт нэмэгдүүлэхийн тулд тооцоолсон цэвэр мөнгөн гүйлгээг зориудаар дутуу илэрхийлэх нь уг хэмжилт нэг талыг барьсан, хазайлт хэлбийлтэнд хүргэх юм.
- (в) Тооцоолсон мөнгөн гүйлгээ буюу дискаунтын түвшин нь хамгийн магадлалтай нэг дүнг, боломжит хамгийн өндөр буюу хамгийн бага дүнг биш, харин боломжит үр дүнгүүдийн мужийг тусгасан байвал зохино.

*Өнөөгийн үнэ цэнийн уламжлалт ба хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний арга хандлага*

### **Уламжлалт арга хандлага**

- МЗУ4. Өнөөгийн үнэ цэнийн талаархи нягтлан болох бүртгэлийн хэрэглээ нь уламжлал ёсоор нэг цогц тооцоолсон мөнгөн гүйлгээ болон дискаунтын нэг хувийг ашигладаг бөгөөд үүнийг ихэвчлэн “эрсдэлд тохирох түвшин” гэж тодорхойлдог байсан. Чухамдаа, нэг дискаунтын хувийн утга нь ирээдүйн мөнгөн гүйлгээ ба холбогдох эрсдлийн урамшууллын талаархи бүх хүлээлтийг нэгтгэн тусгаж чадна гэж уламжлалт арга хандлага үздэг байсан. Иймээс уламжлалт арга хандлага нь дискаунтын хувийг сонгоход гол анхаарлаа хандуулдаг.
- МЗУ5. Зэрэгцүүлэгдэх хөрөнгийг тухайн зах зээлээс олж болно гэх мэт зарим нөхцөл байдалд уламжлалт арга хандлагыг хэрэглэхэд ихээхэн хялбар байдаг. Гэрээнд заасан мөнгөн гүйлгээ бүхий хөрөнгийн хувьд түүний өгөөж нь жишээлбэл, “12 хувийн хүүтэй бонд” гэх мэтээр зах зээлд оролцогчдын тодорхойлох дүнтэй тохирдог.
- МЗУ6. Гэвч уламжлалт арга хандлага нь тухайн хөрөнгөнд хамаарах зах зээлгүй буюу зэрэгцүүлэх хөрөнгөгүй санхүүгийн бус хөрөнгийн хэмжилт гэх мэт



хэмжилтийн зарим нарийн түвэгтэй асуудлуудыг зохих ёсоор авч үздэггүй байж болох юм. “Эрсдэлд тохирох түвшин”-ий талаархи зохих эрэл хайгуул нь зах зээлд оршин буй хөрөнгө ба тухайн хэмжиж буй хөрөнгөнд тохирох хүүний түвшин гэсэн наад зах нь хоёр зүйлсийн шинжилгээ хийхийг шаарддаг. Тухайн хэмжиж буй мөнгөн гүйлгээнд тохирох дискуантын хувийг бусад хөрөнгийн мэдэгдэж буй хүүний түвшнээс гаргалгаа хийж, тооцох ёстой. Ингэж гаргалгаа хийхийн тулд уг бусад хөрөнгийн мөнгөн гүйлгээний шинж чанарууд нь тухайн хэмжиж буй хөрөнгийн мөнгөн гүйлгээний шинж чанартай ижил төсөөтэй байвал зохино. Иймээс хэмжигч нь дараах зүйлсийг гүйцэтгэх шаардлагатай:

- (а) Дискаунтчлах цогц мөнгөн гүйлгээг тодорхойлох;
- (б) Мөнгөн гүйлгээний ижил төсөөтэй шинж чанартай байхаар харагдаж буй уг зах зээл дэх бусад хөрөнгийг тодорхойлох;
- (в) Эдгээр нь ижил төсөөтэй эсэхийг (жишээлбэл; тэдгээр нь хоёулаа гэрээний дагуух мөнгөн гүйлгээ эсвэл нэг нь гэрээний дагуух мөнгөн гүйлгээ, нөгөө нь тооцоолсон мөнгөн гүйлгээ эсэх?) магадлах үүднээс уг хоёр зүйлээс бий болсон цогц мөнгөн гүйлгээнүүдийг зэрэгцүүлэх;
- (г) Нэг зүйлд нь байхгүй элемент нөгөө зүйлд нь байгаа эсэхийг үнэлэх (жишээлбэл; нэг нь нөгөөгөөс хөрвөх чадвар багатай эсэх?); ба
- (д) Эдгээр цогц мөнгөн гүйлгээний аль аль нь эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлттэй ижил төсөөтэй байдлаар хувирах (өөрөөр хэлбэл, өөрчлөгдөх) магадлалтай эсэхийг үнэлэх.

### **Хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний арга хандлага**

МЗУ7. Хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний арга хандлага нь зарим тохиолдолд уламжлалт хандлагаас илүү үр дүнтэй хэмжилтийн арга хэрэгсэл болдог. Хэмжилтийг хийхдээ, уг хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний арга хандлага нь хамгийн магадлалтай нэг мөнгөн гүйлгээг биш, харин боломжит мөнгөн гүйлгээнүүдийн талаархи бүх хүлээлтийг тусгадаг. Жишээлбэл; мөнгөн гүйлгээ нь 100ТН<sup>2</sup>, 200ТН, 300ТН байх магадлал нь харгалзан 10%, 60%, 30% байж болох юм. Эндээс хүлээгдэж буй мөнгөн гүйлгээ нь 220ТН болно. Хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний арга хандлага нь тухайн авч үзэж буй мөнгөн гүйлгээний шууд шинжилгээ болон уг хэмжилтэнд ашиглах таамаглалуудын илүү дэлгэрэнгүй, тодорхой мэдэгдэлд төвлөрдөгөөрөө уламжлалт арга хандлагаас ялгаатай юм.

МЗУ8. Хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний арга хандлага нь мөнгөн гүйлгээний хугацаа тодорхойгүй байх үед мөн өнөөгийн үнэ цэнийн арга зүй ашиглахыг зөвшөөрдөг. Жишээлбэл; 1,000ТН-ийн мөнгөн гүйлгээг нэг дэх жилд, хоёр дахь жилд, гурав дахь жилд авах магадлал нь харгалзан 10%, 60%, 30% байж болох юм. Энэ тохиолдолд хүлээгдэж буй өнөөгийн үнэ цэнийн тооцооллыг доорх жишээгээр харуулав:

---

<sup>2</sup> Энэ болон бусад жишээнд мөнгөн дүнг “тооцооны нэгж” (ТН)-ээр илэрхийлсэн.

МӨНГӨ БИЙ БОЛГОГЧ ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

1,000ТН-ийн өнөөгийн үнэ цэнэ, 1 дэх жилд 5%-иар	952.38ТН	
Магадлал	<u>10%</u>	95.24ТН
1,000ТН-ийн өнөөгийн үнэ цэнэ, 2 дахь жилд 5.25%-иар	902.73ТН	
Магадлал	<u>60%</u>	541.64ТН
1,000ТН-ийн өнөөгийн үнэ цэнэ, 3 дахь жилд 5.50%-иар	851.61ТН	
Магадлал	<u>30%</u>	255.48ТН
Хүлээгдэж буй өнөөгийн үнэ цэнэ		<u>892.36ТН</u>

МЗУ9. Энэхүү 892.36ТН-ийн хүлээгдэж буй өнөөгийн үнэ цэнэ нь уламжлалт хандлагын дагуух хамгийн сайн тооцоолол болох 902.73ТН-ээс (60%-ийн магадлалтай) өөр байна. Энэ жишээнд хамаарах өнөөгийн үнэ цэнийн уламжлалт тооцоолол нь тухайн ашиглах мөнгөн гүйлгээний боломжит хугацааны талаар шийдвэр гаргахыг шаарддаг бөгөөд ингэснээр бусад хугацааны магадлалыг харгалзан тусгахгүй. Яагаад гэвэл, өнөөгийн үнэ цэнийн уламжлалт тооцоолол дахь дискаунтын хувь нь цаг хугацааны тодорхой бус байдлыг тусгаж чаддаггүй.

МЗУ10. Магадлалыг ашиглах нь хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний арга хандлагын чухал элемент юм. Ихээхэн субъектив тооцоололд магадлалыг хуваарилах нь бодит байдлаас илүү оновчтой тооцооллыг илэрхийлж чадах уу гэсэн зарим асуулт гардаг. Хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний аргатай адилаар тооцооллыг ил тод харуулахгүй боловч уламжлалт арга хандлагын зохих хэрэглээ нь (МЗУ6-р параграфт дурдсан) мөн адил тооцоолол ба субъектив тооцоо хийхийг шаарддаг.

МЗУ11. Өнөөгийн практикт боловсруулан гаргасан олон тооцоолол нь энэхүү хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний элементүүдийг албан бусаар нэгтгэн оруулсан байдаг. Түүнчлэн, нягтлан бодогч нар нь боломжит мөнгөн гүйлгээний магадлалын талаархи маш хязгаарлагдмал мэдээллийг ашигласнаар хөрөнгийг хэмжих шаардлагатай байнга тулгарч байдаг. Жишээлбэл; нягтлан бодогч нь дараах нөхцөл байдалтай тулгарч болох юм:

- (а) Тооцоолсон дүн нь 50ТН ба 250ТН-ийн хооронд байгаа боловч энэхүү мужид хамаарах аль нэг тоо нь бусад дүнгээс илүү магадлалтай биш байна. Ийм хязгаарлагдмал мэдээлэлд үндэслэн тооцоолсон хүлээгдэж буй мөнгөн гүйлгээ нь  $150ТН [(50+250)/2]$  болно.
- (б) Тооцоолсон дүн нь 50ТН ба 250ТН-ийн хооронд байгаа бөгөөд хамгийн магадлалтай дүн нь 100ТН юм. Гэхдээ дүн бүрд хамаарах магадлал нь тодорхойгүй байна. Ийм хязгаарлагдмал мэдээлэлд үндэслэн тооцоолсон хүлээгдэж буй мөнгөн гүйлгээ нь  $133.33ТН [(50+100+250)/3]$  болно.
- (в) Тооцоолсон дүн нь 50ТН (10 хувийн магадлалтай), 250ТН (30 хувийн магадлалтай), 100ТН (60 хувийн магадлалтай) байж болох юм. Ийм

## МӨНГӨ БИЙ БОЛГОГЧ ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

хязгаарлагдмал мэдээлэлд үндэслэн тооцоолсон хүлээгдэж буй мөнгөн гүйлгээ  $140\text{ТН} [(50 \times 0.10) + (250 \times 0.30) + (100 \times 0.60)]$  болно.

Тохиолдол тус бүрд тооцоолсон, хүлээгдэж буй мөнгөн гүйлгээ нь ашиглалтын үнэ цэнийн талаархи хамгийн бага, хамгийн магадлалтай, хамгийн их гэсэн ганц дүнгээс илүү сайн тооцооллыг илэрхийлэх магадлалтай юм.

МЗУ12. Хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний арга хандлагыг хэрэглэх эсэх нь зардал-өгөөжийн шалгуураас хамаарна. Зарим тохиолдолд байгууллага нь өргөн хүрээтэй мэдээллийг ашиглан мөнгөн гүйлгээний олон хувилбаруудыг боловсруулан гаргах боломжтой байж болох юм. Харин зарим тохиолдолд байгууллага нь мэдэгдэхүйц их зардал гаргахгүйгээр мөнгөн гүйлгээний хувьсал өөрчлөлтийн талаар ерөнхий мэдэгдэл гаргахаас өөр, илүү их мэдээллийг бэлтгэх боломжгүй байж болно. Байгууллага нь нэмэлт мэдээллийг олж авах зардлыг уг тооцоололд ашиглах мэдээллийн найдвартай байдлыг нэмэгдүүлсэний ач холбогдолтой харгалзан уялдуулах шаардлагатай байдаг.

МЗУ13. Хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний арга зүй нь нэг зүйл эсвэл хязгаарлагдмал тооны боломжит үр дүн бүхий зүйлийг хэмжихэд тохиромжгүй гэж зарим хүмүүс үздэг. Хөрөнгө нь ердөө хоёр боломжит үр дүнтэй байх жишээг тэд иш татдаг. Үүнд: мөнгөн гүйлгээ нь 10ТН байх магадлал 90 хувь, 1,000ТН байх магадлал 10 хувь гэж үзье. Тэд энэ жишээнд хүлээгдэж буй мөнгөн гүйлгээ 109ТН болох бөгөөд эцэстээ төлөгдөж болох хоёр дүнгийн алийг нь ч илэрхийлэхгүй байна гэж шүүмжилдэг.

МЗУ14. Дээр дурдсантай адил мэдэгдлүүд нь хэмжилтийн зорилготой зөрчилдөж байгаа зүйлсийг илэрхийлнэ. Хэрэв зорилго нь гарах өртөг зардлыг хуримтлуулан тооцох явдал байсан бол хүлээгдэж буй мөнгөн гүйлгээ нь тухайн хүлээгдэж буй зардлын үнэн зөв тооцооллыг харуулаагүй байж болох юм. Гэвч энэ Стандарт нь хөрөнгийн нөхөгдөх дүнгийн хэмжилтийг авч үзэж байна. Хэдийгээр хамгийн магадлалтай мөнгөн гүйлгээний дүн боловч энэ жишээнд хөрөнгийн нөхөгдөх дүн нь 10ТН биш байж болно. Яагаад гэвэл, 10ТН гэсэн хэмжилт нь мөнгөн гүйлгээний тодорхой бус байдлыг уг хөрөнгийн хэмжилтэнд харгалзан үзээгүй. Харин тодорхой бус мөнгөн гүйлгээг тодорхой мөнгөн гүйлгээ шиг илэрхийлж байна. Зохих бодлоготой байгууллага нь ийм шинж чанар бүхий хөрөнгөө 10ТН-ээр борлуулахгүй юм.

### *Дискаунтын түвшин*

МЗУ15. Байгууллага нь хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг хэмжихдээ аль ч арга хандлагыг хэрэглэсэн байлаа гэхэд мөнгөн гүйлгээг дискаунтчлахын тулд ашигласан хүүний түвшин нь уг тооцоолсон мөнгөн гүйлгээг тохируулах эрсдлийг тусгаагүй байвал зохино. Хэрэв ийнхүү тусгавал зарим таамаглалуудын үр нөлөөг давхардуулан тооцох юм.

## МӨНГӨ БИЙ БОЛГОГЧ ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

МЗУ16. Хөрөнгөд тусгайлан харгалзах хувь хэмжээг зах зээлээс шууд тодорхойлох боломжгүй тохиолдолд байгууллага нь дискаунтын хувийг тооцоолохын тулд орлох хувийг ашиглана. Үүний зорилго нь доорх зүйлсийн зах зээлийн үнэлгээг аль болох боломжит хэмжээгээр тооцоолох явдал юм:

- (а) Тухайн хөрөнгийн ашиглалтын хугацааны эцэс хүртэлх тайлант үеүдийн мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ; ба
- (б) Тооцоолсон мөнгөн гүйлгээг гаргахад тохируулга хийхэд хүргэхээргүй байх тэр хэмжээгээр МЗУ1-р параграфт дурдсан (б), (г), (д) хүчин зүйлс.

МЗУ17. Ийм тооцоолол хийх эхлэлийн цэг болгон байгууллага нь дараах хувь хэмжээнүүдийг харгалзан үзэж болох юм:

- (а) Капитал Хөрөнгийн Үнэ Тогтоох Загвар гэх мэт арга зүйг ашиглан тодорхойлсон уг байгууллагын капиталын жинэлсэн дундаж өртөг;
- (б) Байгууллагын өсөн нэмэгдэх зээлийн хүүний хувь; ба
- (в) Зах зээлийн бусад зээлийн хүү.

МЗУ18. Гэхдээ дараах зүйлсийг гүйцэтгэхийн тулд эдгээр хувь хэмжээнүүдийг тохируулах ёстой:

- (а) Тухайн хөрөнгийн тооцоолсон мөнгөн гүйлгээтэй холбоотой тусгай эрсдлийг уг зах зээлээр үнэлэх байсан арга замыг тусгах; ба
- (б) Хөрөнгийн тооцоолсон мөнгөн гүйлгээнд хамааралгүй эсвэл тухайн эрсдлийн хувьд тооцоолсон мөнгөн гүйлгээг тохируулсан тийм эрсдлийг хасах.

Улс орны эрсдэл, валютын эрсдэл, үнийн эрсдэл гэх мэт эрсдлийг анхаарах хэрэгтэй.

МЗУ19. Хөрөнгөөс бий болохоор хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн гүйлгээ нь тухайн хөрөнгийн худалдан авалтыг уг байгууллага санхүүжүүлсэн арга замаас хамаарахгүй тул дискаунтын хувь нь байгууллагын капиталын бүтэц болон хөрөнгийн худалдан авалтыг тэрхүү байгууллага санхүүжүүлсэн арга замаас хамааралгүй байна.

МЗУ20. Ашиглах дискаунтын хувь нь татварын өмнөх хувь байхыг 68-р параграфтаар шаардсан байдаг. Иймээс дискаунтын хувийг тооцоолоход ашигласан суурь нь татварын дараах хувь хэмжээ бол татварын өмнөх хувь хэмжээг тусгахын тулд уг суурийг тохируулна.

МЗУ21. Байгууллага нь хөрөнгийн ашиглалтын үнэ цэнийг тооцоолохдоо ихэвчлэн нэг дискаунтын хувийг ашигладаг. Гэвч ашиглалтын үнэ цэнэ нь ирээдүйн өөр өөр тайлант үеүд дэх эрсдлийн ялгаатай байдлаас эсвэл хүүний түвшний хугацааны бүтцээс хамаарах мэдрэмжтэй тохиолдолд байгууллага нь ирээдүйн өөр өөр тайлант үеүдэд дискаунтын өөр өөр хувиудыг ашиглана.

## Хавсралт Б

### Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт

[Хассан]

## Дүгнэлтийн Үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 26-г дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

**НББОУС3-ийн 2004 онд гаргасан, НББОУС 36-гийн хянан засварласан хувилбарт үндэслэн УСНББОУС 26-г боловсруулсан.**

*Оршил*

- ДҮ1. УСНББОУС3-ийн СТОУС-тай нийцүүлэх хөтөлбөр нь УСНББОУС3-ийн ажлын хөтөлбөрийн чухал элемент юм. УСНББОУС3-ийн бодлого нь улсын секторын байгууллагуудад тохиромжтой тохиолдолд НББОУС3-өөс гаргасан СТОУС-тай аккруэл суурьт УСНББОУС-ыг нийцүүлэх явдал юм.
- ДҮ2. УСНББОУС3 нь 2004 оны 12 дугаар сард УСНББОУС 21, *Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-ыг гаргасан. УСНББОУС 21 нь мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэхийг тодорхойлох ба уг үнэ цэнийн бууралтыг хэрхэн хүлээн зөвшөөрч, хэмжихийг тогтоохдоо тухайн байгууллагын мөрдөх горимуудыг заан илэрхийлдэг. Улсын секторын ихэнх хөрөнгө нь мөнгө бий болгодоггүй бөгөөд боловсруулсан хүлээн зөвшөөрөлтийн болон хэмжилтийн шаардлагууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) 36, *Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-аас УСНББОУС 21-ийг олон зүйлийн хувьд өөр болгоход хүргэдэг.

*Энэ Стандартын хэрэгцээ шаардлага*

- ДҮ3. Уншигч хэрэглэгчид нь (а) мөнгө бий болгогч хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэхийг тогтоох, ба (б) аливаа үнэ цэнийн бууралтын хүлээн зөвшөөрөлт болон хэмжилтийг тайлагнахдаа НББОУС 36-г лавлагаа болгохыг УСНББОУС 21-д заасан байдаг. Улсын секторын байгууллага нь мөнгө бий болгогч хөрөнгөтэй байх тохиолдолд НББОУС 36-г лавлагаа болгон үзэх шаардлагатай болгохгүйн тулд мөнгө бий болгогч хөрөнгийн үнэ цэнийн бууралтын талаархи шаардлагууд ба заавар удирдамжийг УСНББОУС-д нэгтгэн оруулах нь ач холбогдолтой юм. Түүнчлэн, үнэ цэнийн бууралттай холбоотой улсын секторын шийдвэрлэх олон асуудлууд байдаг. Үүнд дараах зүйлс хамаарна:
- (а) УСНББОУС 17, *Үндсэн хөрөнгө*-д заасан дахин үнэлгээний загварын дагуу тайлагнасан, мөнгө бий болгогч үндсэн хөрөнгө нь энэ Стандартын цар хүрээнд хамаарах эсэх;
  - (б) Мөнгө бий болгогч ба мөнгө бий болгодоггүй хөрөнгүүдийг салган зааглах;
  - (в) Мөнгө бий болгогч хөрөнгийг мөнгө бий болгодоггүй хөрөнгө болгон дахин ангилах эсвэл эсрэгээр дахин ангилах; ба
  - (г) Мөнгө бий болгогч нэгжүүд дэх мөнгө бий болгодоггүй хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралтын зорилгоорх тайлагнал.

*Дахин үнэлсэн дүнгээр тайлагнасан үндсэн хөрөнгө ба бодит үнэ цэнээр байнга дахин үнэлдэг биет бус хөрөнгийг энэ Стандартын цар хүрээнд хамруулахгүй*

- ДҮ4. УСНББОУС 17-д заасан дахин үнэлгээний загварын дагуу дахин үнэлсэн дүнгээр бүртгэсэн, мөнгө бий болгодоггүй үндсэн хөрөнгө нь 2008 оны 02 дугаар сард энэ Стандартыг гаргах үед УСНББОУС 21-ийн цар хүрээнд хамаардаггүй байсан. УСНББОУС3 нь УСНББОУС 17-д заасан дахин үнэлгээний загварын дагуу дахин үнэлсэн дүнгээр бүртгэдэг хөрөнгийг (а) тухайн тайлангийн өдрөөрх түүний бодит үнэ цэнээс материаллаг зөрүүгүй байх тийм дүнгээр бүртгэсэн, ба (б) аливаа үнэ цэнийн бууралтыг тэрхүү үнэлгээнд харгалзан тусгадаг эсэхийг ханган магадлахын тулд хөрөнгийг хангалттай тогтмол дахин үнэлдэг гэсэн үзэл бодолтой байдгийг УСНББОУС 21-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тэмдэглэсэн. Иймээс УСНББОУС3 нь цар хүрээг хязгаарлах үүнтэй адилтгах заалтыг энэ Стандартад оруулах хэрэгтэй эсэхийг харгалзан үзсэн.
- ДҮ5. Дахин үнэлгээний загварын дагуу эзэмшиж буй үндсэн хөрөнгө нь НББОУС 36-гийн цар хүрээнд хамаарна гэдгийг УСНББОУС3 мэдэгдсэн бөгөөд ийм хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын гарзыг тодорхойлох заавар удирдамж нь дахин үнэлгээний загварын дагуу тайлагнасан тийм хөрөнгө бүхий улсын секторын байгууллагын хувьд тохиромжтой эсэх үзэл баримтлалыг мөн харгалзан үзсэн. Үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь түүний зах зээлийн үнэ цэнэ байх тохиолдолд үнэ цэнийн бууралтын гарзын хамгийн их дүн нь түүний данснаас хасалтын зардал байна гэдгийг УСНББОУС3 нь НББОУС 36-д тэмдэглэсэн. “УСНББОУС3-ийн үзэл бодлоор бол энэ нь ихэнх тохиолдолд материаллаг бус байх бөгөөд практик үүднээс авч үзвэл, тухайн хөрөнгийн нөхөгдөх үйлчилгээний дүнг хэмжих ба мөнгө бий болгодоггүй хөрөнгийн данснаас хасалтын зардлын хувьд үнэ цэнийн бууралтын гарз хүлээн зөвшөөрөх шаардлагагүй” гэж УСНББОУС 21-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тэмдэглэсэн. Данснаас хасалтын зардал нь уг мөнгө бий болгогч хөрөнгийн хувьд материаллаг байх магадлал багатай эсэхийг УСНББОУС3 бас харгалзан үзсэн.
- ДҮ6. Бодит үнэ цэнийг нь зах зээлийн үнэ цэнээр тодорхойлдоггүй, тусгай зориулалтын мөнгө бий болгогч хөрөнгийн хувьд НББОУС 36 нь нөхөгдөх байдлыг түүний ашиглалтын үнэ цэнээр тооцоолохыг шаарддаг. Ашиглалтын үнэ цэнэ нь мөнгөн гүйлгээний төсөвлөлтөнд үндэслэдэг учраас энэ нь дансны үнээс материаллагаар их буюу бага байж болох юм. Ийм шинжилгээ нь мөн улсын секторт бас хамааралтай байдаг. Гэвч улсын секторын байгууллагууд нь энэ Стандартад заасан, мөнгө бий болгогч хөрөнгийн тодорхойлолтыг хангах тусгай зориулалтын хөрөнгийг эзэмшдэг эсэх нь эргэлзээтэй байдаг.
- ДҮ7. УСНББОУС 17-гийн одоогийн шаардлагуудаас, тухайлбал; хөрөнгийг тухайн тайлангийн өдрөөрх түүний бодит үнэ цэнээс материаллагаар зөрүүтэй биш тийм дүнгээр бүртгэсэн эсэхийг ханган магадлахын тулд хангалттай тогтмол дахин үнэлэх шаардлагаас гадна үнэ цэнийн бууралтын сорил хийх шаардлага тавих нь буруу гэж УСНББОУС3 үздэг.

Энэ бүгдийг харгалзан үзсэний үндсэн дээр УСНББОУСЗ нь НББОУС 36-тай нийцүүлэхийн оронд УСНББОУС 21-ийг дагаж мөрдөх нь илүү давуу талтай бөгөөд УСНББОУС 17-д заасан дахин үнэлгээний загварын дагуу тайлагнасан үндсэн хөрөнгийг энэ Стандартын цар хүрээнд хамруулахгүй байх хэрэгтэй гэж дүгнэсэн. Бодит үнэ цэнээр байнга дахин үнэлдэг биет бус хөрөнгийг дээрх үндсэн хөрөнгөнд баримталдаг арга хандлагын дагуу энэхүү Стандартын цар хүрээнээс бас хассан.

**Дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (УСНББОУС 21 ба УСНББОУС 26-гийн нэмэлт өөрчлөлтүүд)**

- ДҮ7А. УСНББОУС-уудыг мөрдөж буй улс орнуудаас гаргасан хүсэлтийн үр дүнд 2015 онд УСНББОУСЗ нь дахин үнэлсэн үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийг УСНББОУС 26-гийн цар хүрээнээс хасах тухай өөрийн анхны шийдвэрийг эргэн харсан.
- ДҮ7Б. УСНББОУС 26 ба НББОУС 36-ийн ялгаатай шаардлагуудын талаархи дээрх ДҮ5 болон ДҮ6-р параграфууд дахь шалтгаан үндэслэл нь хүчин төгөлдөр хэвээр байна гэж УСНББОУСЗ үзсэн. УСНББОУС 17-гийн 44-р параграф ба УСНББОУС 31-ийн 74-р параграфаар шаардсанчлан, хөрөнгийн дансны үнэ нь түүний бодит үнэ цэнээс материаллаг зөрүүгүй гэдгийг ханган магадлахын тулд хөрөнгийн дахин үнэлгээг хийдэг тохиолдолд үнэ цэнийн бууралтыг харгалзан үзнэ гэсэн байр суурьтай байгаагаа УСНББОУСЗ мэдэгдсэн.
- ДҮ7В. Үнэ цэнийн бууралтын гарз ба үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтыг дахин үнэлгээтэй төсөөтэй байдлаар тайлагнадаг гэдэгт үндэслэн тэдгээр нь дахин үнэлгээ эсэх хоёрдмол утга үүсэж байгааг УСНББОУСЗ мөн онцлон тэмдэглэсэн. Хэрэв үндсэн хөрөнгийн тодорхой нэг ангид харъяалагдах үндсэн хөрөнгийн зүйлийг дахин үнэлсэн бол тэдгээр хөрөнгүүдийн нийт ангийг дахин үнэлэхийг УСНББОУС 17-гийн 51-р параграфаар шаардсан байдаг. Иймээс үнэ цэнийн бууралтын гарз ба үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтыг дахин үнэлгээ гэж тайлбарлавал үр дагавар нь алдаатай болох юм. УСНББОУСЗ нь үүнийг хоёрдмол утгатай байдлаар шийдвэрлэвэл зохино гэж үзсэн.
- ДҮ7Г. УСНББОУСЗ нь УСНББОУС 26-гийн 120 ба 121-р параграфуудад тусгайлан заасан үнэ цэнийн бууралтын тоон болон чанарын шинжтэй мэдээллээр хэрэглэгчдийг хангах нь чухал ач холбогдолтой гэж бас үзсэн.
- ДҮ7Д. УСНББОУС 21-ийн дагуу дээрх хоёрдмол утгыг тодруулах УСНББОУСЗ-ийн зорилго бол дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз ба үнэ цэнийн бууралтын гарзын буцаалт нь уг дахин үнэлсэн зүйлийн хувьд үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөхийн тулд тэрхүү зүйлийн харъяалагдах хөрөнгийн нийт ангийг дахин үнэлэхийг тухайн байгууллагаас шаардахгүй гэдгийг ханган магадлах явдал юм.
- ДҮ7Е. Дахин үнэлсэн дүнгээр хэмждэг үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийг УСНББОУС 26-гийн цар хүрээнд хамруулан оруулах нь тухайн хөрөнгийн



үнэ цэнэ буурсан байж болох аливаа шинж тэмдэг байгаа эсэхийг уг байгууллага жил бүр үнэлэх шаардлагатай гэдгийг илэрхийлэх боловч тэрхүү байгууллага нь үнэ цэнийн бууралтын аливаа шинж тэмдгүүдийг мэдэх магадлалтай байдаг. Иймээс дахин үнэлсэн дүнгээр хэмждэг үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийг УСНББОУС 26-гийн цар хүрээнд хамруулан оруулах нь санхүүгийн тайлан бэлтгэгчийн хувьд ноцтой алдаа болохгүй гэж УСНББОУСЗ дүгнэсэн.

ДҮ7Ж. Эдгээр анхаарах зүйлсийн улмаас УСНББОУСЗ нь СТ 57, *Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-ыг 2015 оны 9 дүгээр сард батлан гаргасан бөгөөд энэхүү СТ-г дараа сард нь хэвлэн нийтэлсэн.

### **СТ 57-д өгсөн хариултууд**

ДҮ7И. СТ57-д хариу өгсөн ихэнх хүмүүс нь уг санал болон УСНББОУСЗ-ийн шалтгаан үндэслэлийг дэмжсэн. Дахин үнэлсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз ба үнэ цэнийн бууралтын гарзын буцаалт нь тэрхүү зүйлийн харъяалагдах хөрөнгийн нийт ангийг дахин үнэлэхийг тухайн байгууллагаас шаардахгүй гэсэн тодруулгад УСНББОУС 17 дахь энгийн мэдэгдлээр илүү хялбархан хүрч болно гэсэн саналыг УСНББОУСЗ авч үзсэн.

ДҮ7К. УСНББОУСЗ нь ийм үзэл бодлыг мэдэгдсэн боловч хоёр шалтгааны улмаас түүнийг тохиромжгүй гэж үзсэн. Нэгдүгээрт, хөрөнгийн нөхөгдөх үйлчилгээний дүнг үнэлэх үед ийм хандлага нь мөнгө бий болгодоггүй хөрөнгүүдийн ашиглалтын үнэ цэнийг тодорхойлох янз бүрийн аргуудыг хангалттай харгалзан үздэггүй. Ийм аргууд нь элэгдэл тооцсон орлуулалтын өртгийн хандлага, нөхөн сэргээлтийн өртгийн хандлага, үйлчилгээний нэгжийн хандлага юм. Хоёрдугаарт, уг хандлага нь УСНББОУС 21 ба УСНББОУС 26-д тодруулгын заалт оруулснаар хэрэглэгчдийн тайлагналын хариуцлагын болон шийдвэр гаргалтын зорилгод шаардлагатай мэдээллээр хангахгүй юм. Иймээс УСНББОУСЗ нь СТ 57 дахь өөрийн саналуудаа эцсийн тунхаглалд хүчин төгөлдөр болгон оруулахаар шийдвэрлэсэн.

ДҮ7Л. СТ-д өгсөн хариултуудыг харгалзан үзсэний дараа, УСНББОУСЗ нь үнэ цэнийн бууралт бол дахин үнэлгээний бууралтаас онолын хувьд ялгаатай гэсэн СТ 57-гийн Дүгнэлтийн Үндэслэлийн батламж мэдэгдлийг дахин хянан үнэлсэн. Үнэ цэнийн бууралт ба дахин үнэлгээний бууралтын аль аль нь үйлчилгээний чадавхи буюу эдийн засгийн үр өгөөж бий болгох чадвар боломжийн бууралтыг агуулдаг учраас эдгээр нь онолын хувьд ижил гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Гэвч практикт ялгаатай талууд байдаг. Үнэ цэнийн бууралт нь үечилсэн дахин үнэлгээний үр дүнд биш, харин бие даасан хөрөнгө буюу хөрөнгүүдийн бүлэгт нөлөө үзүүлдэг үйл явдал юм. “УСНББОУС 21 ба УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-ын дагуу тооцох үнэ цэнийн бууралтын гарз болон үнэ цэнийн бууралтын гарзын буцаалт нь тэрхүү хөрөнгө буюу хөрөнгүүдийн бүлгийн харъяалагдах хөрөнгийн ангийг дахин үнэлэх хэрэгцээ шаардлагыг заавал үүсгэн бий болгохгүй” гэсэн мэдэгдлийг УСНББОУС

17-гийн 51А параграфт оруулснаар энэхүү практикын ялгаатай байдлыг тусгасан.

*Гүүдвилийг энэ Стандартын цар хүрээнд хамруулахгүй байх*

ДҮ8. НББОУС 36 нь (а) гүүдвилийн үнэ цэнийн бууралт, (б) гүүдвилийг мөнгө бий болгогч нэгжүүдэд хуваарилалт, (в) гүүдвил бүхий мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтын сорилын талаархи дэлгэрэнгүй шаардлага ба заавар удирдамжийг агуулсан байдаг. УСНББОУС 26-г боловсруулах үедээ УСНББОУС3 нь энэхүү Стандартын цар хүрээнд гүүдвилийг хамааруулах хэрэгтэй эсэхийг харгалзан үзсэн. УСНББОУС3 нь улсын секторын байгууллагын нэгдлийг зохицуулах УСНББОУС-ыг хараахан гаргаагүй байсан бөгөөд улсын секторын байгууллагуудын нэгдэл хийгдсэн тохиолдолд улсын секторын олон тооны тусгай асуудлууд үүсэх магадлалтай гэж үзсэн. Тухайлбал; улсын секторын байгууллагуудын нэгдлийн хувьд нэгтгэгчийг тодорхойлж чадах эсэх. УСНББОУС3 нь гүүдвилийг энэхүү Стандартын цар хүрээнд хамруулах хэрэггүй гэж үзсэн. Гүүдвилийн үнэ цэнийн бууралт, мөнгө бий болгогч нэгжүүдэд гүүдвилийн хуваарилалт, гүүдвил бүхий мөнгө бий болгогч нэгжийн үнэ цэнийн бууралтын сорилыг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартуудын шаардлагуудыг хэрглэгчид нь УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого*, *Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-нд заасан эрэмбэ дарааллын лавлагаа болгон харгалзан үзнэ.

ДҮ8А. УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийг 2017 оны 01 дүгээр сард гаргасан. УСНББОУС 40 нь гүүдвилийг хүлээн зөвшөөрөх ба хэмжих шаардлагуудыг агуулсан байдаг. УСНББОУС 40-ийг боловсруулахдаа, УСНББОУС3 нь гүүдвиллийн үнэ цэнийн бууралтын шаардлагуудыг харгалзан үзсэн. Гүүдвилл нь бусад хөрөнгүүдээс бие даасан байдлаар эдийн засгийн үр өгөөж бий болгодоггүй, иймээс хөрөнгүүдийн бүлгийн нэг хэсэг байдлаар түүний үнэ цэнийн бууралтыг үнэлнэ гэдгийг УСНББОУС3 онцлон тэмдэглэдэг. Эерэг мөнгөн орлогын гүйлгээ эсвэл цэвэр мөнгөн зарлагын гүйлгээний бууралт эсэхээс үл хамааран мөнгөн гүйлгээг зөвхөн лавлагаа болгосноор гүүдвиллийг хэмжиж болно. УСНББОУС 21 нь зөвхөн бие даасан хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралтыг авч үздэг бөгөөд тухайн хөрөнгийн үлдсэн үйлчилгээний чадавхийн өнөөгийн үнэ цэнийг харгалзсанаар үнэ цэнийн бууралтыг үнэлдэг гэдгийг УСНББОУС3 мөн тэмдэглэсэн байдаг. Иймээс УСНББОУС3 нь гүүдвиллийн үнэ цэнийн бууралтанд УСНББОУС 21-ийг мөрдөх нь тохиромжгүй гэж дүгнэсэн. Гүүдвиллийн хамаарах үйл ажиллагаа нь мөнгө бий болгогч үйл ажиллагаа эсэхээс үл хамааран үнэ цэнийн бууралтын зорилгоор гүүдвиллийг мөнгө бий болгогч хөрөнгө гэж үзвэл зохино гэж УСНББОУС3 дүгнэсэн. УСНББОУС3 нь үнэ цэнийн бууралтын зорилгоор гүүдвиллийг мөнгө бий болгогч хөрөнгө гэж үзэх нэмэлт заавар удирдамжийг УСНББОУС 21 ба УСНББОУС 26-д тусган оруулахыг зөвшөөрсөн.

ДҮ8Б. Үнэ цэнийн бууралтын зорилгоор гүүдвилийг мөнгө бий болгогч хөрөнгө гэж үзэх хэрэгтэй гэсэн УСНББОУС3-ийн шийдвэрийн үр дүн болгон

## МӨНГӨ БИЙ БОЛГОГЧ ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

УСНББОУСЗ нь (а) гүүдвилийн үнэ цэнийн бууралт, (б) мөнгө бий болгогч нэгжүүдэд гүүдвилийн хуваарилалт, (в) гүүдвил бүхий мөнгө бий болгогч нэгжүүдийг НББОУС 36-д заасан үнэ цэнийн бууралтын хувьд сорьж шалгалт зэргийн талаархи дэлгэрэнгүй шаардлагууд болон заавар удирдамжийг УСНББОУС 26-д тусган оруулахыг зөвшөөрсөн.

### *Мөнгө бий болгогч ба мөнгө бий болгодоггүй хөрөнгүүдийг ялган зааглах*

ДҮ9. Зарим хөрөнгө нь мөнгө бий болгогч ба мөнгө бий болгодоггүй хөрөнгүүдийн аль алины шинж чанаруудыг агуулсан байдаг гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. УСНББОУСЗ нь хөрөнгийн мөнгө бий болгогч ба мөнгө бий болгодоггүй бүрэлдэхүүн хэсгүүдийг тогтоох, ингэснээр тэдгээрийг өөр өөр хандлагаар авч үзэх бүрэлдэхүүнд-үндэслэсэн хандлагыг хэрэглэх хэрэгтэй эсэхийг авч үзсэн. Өртөг-өгөөжийн хязгаарлалтын улмаас УСНББОУСЗ нь энэ хандлагаас татгалзсан. Улсын секторын хөрөнгүүд нь ерөнхийдөө мөнгө бий болгодоггүй хөрөнгүүд бөгөөд тэдгээрийн үйлчилгээний чадавхийн шинжилгээ нь үнэ цэнийн бууралтыг тодорхойлох гол суурь болно гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Иймээс мөнгө бий болгогч ба мөнгө бий болгодоггүй хөрөнгүүдийн аль алиныг мөнгө бий болгодоггүй хөрөнгө гэж үзэх хэрэгтэй гэсэн няцааж болох урьдчилсан нөхцлийг энэ Стандартын 18-р параграфт тусган оруулсан.

### *Үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг: Зах зээлийн капиталжуулалт*

ДҮ10. Улсын секторын байгууллагуудын эзэмшиж буй мөнгө бий болгогч хөрөнгийн үнэ цэнийн бууралтын шинж тэмдгүүд нь НББОУС 36-д заасан шинж тэмдгүүдтэй ижил төсөөтэй эсэхийг УСНББОУСЗ нь энэ Стандартыг гаргах үедээ харгалзан үзсэн. Байгууллагын цэвэр хөрөнгийн дансны үнэ нь түүний зах зээлийн капиталжуулалтын үнэ цэнээс илүү гэсэн шинж тэмдгээс бусад, НББОУС 36 дахь шинж тэмдгүүд нь хамааралтай гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Энэ Стандартыг гаргах үед УСНББОУСЗ-ийн үзэл бодлоор бол [УҮГ] (2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргаснаас хойш ийм дөрвөлжин хаалтанд тусгасан нэр томъёог цаашид ашиглахаа больсон) биш, улсын секторын маш цөөн байгууллагууд нь өргөн зах зээлд арилжаалах өмчийн хэрэглүүрүүдийг гаргадаг байсан бөгөөд иймээс уг шинж тэмдэг нь зөвхөн УҮГ-ын нэгтгэлд хамааралтай юм.

### *Борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ ба албадан борлуулалт*

ДҮ11. “Борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ”-ийн тодорхойлолтын талаархи тайлбарт НББОУС 36 нь “борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ нь албадан борлуулалтыг илэрхийлэхгүй” гэж заасан боловч “удирдлага нь хөрөнгийг нэн даруй худалдан борлуулах шахалт шаардлагад орсноос бусад” гэсэн шалгуурыг тусган оруулсан. [УҮГ] (2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргаснаас хойш ийм дөрвөлжин хаалтанд тусгасан нэр томъёог цаашид ашиглахаа больсон) биш, улсын секторын байгууллагууд нь тасралтгүй

## МӨНГӨ БИЙ БОЛГОГЧ ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

байдлаар үйл ажиллагаагаа явуулахын тулд нэн даруй борлуулалт хийх албадан шаардлагад орох маш цөөн тохиолдол байдаг учраас УСНББОУС 26 нь ийм шалгуурыг 40-р параргафт тусган оруулаагүй.

### *Хөрөнгийг дахин ангилах*

ДҮ12. Мөнгө бий болгогч хөрөнгө нь мөнгө бий болгодоггүй хөрөнгө болох, эсвэл эсрэг нөхцөл байдал үүсэж болно. Мөнгө бий болгогч хөрөнгийг мөнгө бий болгодоггүй хөрөнгө болгон дахин ангилахыг, эсвэл эсрэгээр дахин ангилахыг ямар нөхцөлд хүлээн зөвшөөрч болох эсэхийг УСНББОУС3 авч үзсэн. Ийм дахин ангилал нь тохиромжтой гэсэн тодорхой нотолгоо байгаа зөвхөн тийм тохиолдолд дахин ангиллыг хийнэ гэж УСНББОУС3 дүгнэсэн. Дахин ангилал нь өөрөө үнэ цэнийн бууралтын сорил хийх эсвэл үнэ цэнийн бууралтын гарзыг буцаахад заавал хүргэх албагүй гэж УСНББОУС3 бас дүгнэсэн. Харин дараагийн тайлант үеийн эцэст сорил хийх шаардлагатай эсэхийг тодорхойлохын тулд байгууллага нь уг дахин ангиллын дараах тохиромжтой шинж тэмдгүүдийг үнэлнэ. Эдгээр шаардлагуудыг 112-р параграфт заасан.

### *Мөнгө бий болгогч нэгж*

ДҮ13. НББОУС 36-д зааснаар, бие даасан хөрөнгийн нөхөгдөх дүнг тодорхойлох боломжгүй тохиолдолд тухайн хөрөнгийн мөнгө бий болгогч нэгжийн (МББН) нөхөгдөх дүнг тодорхойлдог. МББН гэдэг нь (а) тасралтгүй ашиглалтаас мөнгөн орлогын гүйлгээ бий болгодог, (б) бусад хөрөнгүүд буюу хөрөнгүүдийн бүлгийн мөнгөн орлогоос бүрэн хамааралгүй байдлаар мөнгөн орлогыг бий болгодог хөрөнгүүдийн тодорхойлж болох хамгийн бага бүлэг юм. МББН гэсэн ойлголт нь улсын секторын хүрэн дэх мөнгө бий болгогч хөрөнгүүдийн хувьд тохиромжтой гэж УСНББОУС3 дүгнэсэн.

### *Корпорацийн хөрөнгө*

ДҮ14. НББОУС 36 нь корпорацийн хөрөнгүүдтэй холбоотой шаардлагуудыг тусгасан байдаг. Корпорацийн хөрөнгийг НББОУС 36-д “тухайн авч үзэж буй мөнгө бий болгогч нэгж ба бусад мөнгө бий болгогч нэгжүүдийн аль алины ирээдүйн мөнгөн гүйлгээнд хувь нэмрээ оруулдаг, гүүдвилээс бусад бүх хөрөнгө” гэж тодорхойлсон байдаг. Өөрөөр хэлбэл, корпорацийн хөрөнгө нь мөнгө бий болгодоггүй үйл ажиллагаанд бус, харин МББН-д хувь нэмрээ оруулдаг. НББОУС 36-д тодорхойлсонтой адилаар корпорацийн хөрөнгийн талаархи шаардлагуудыг энэ Стандартад тусган оруулах хэрэгтэй эсэхийг УСНББОУС3 авч үзсэн.

ДҮ15. [УҮГ] (2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргаснаас хойш ийм дөрвөлжин хаалтанд тусгасан нэр томъёог цаашид ашиглахаа больсон) биш, улсын секторын байгууллагууд нь арилжааны үр өгөөж бий болгох үндсэн зорилгогүй байдаг. Иймээс мөнгө бий болгодоггүй үйл ажиллагаанд өөрийн үйлчилгээний чадавхиар бас хувь нэмрээ оруулахгүйгээр зөвхөн МББН-үүдэд үйлчилгээний

чадавхиараа хувь нэмрээ оруулдаг янз бүрийн үйл ажиллагаануудын хооронд хөрөнгийг (захиргааны барилга гэх мэт) хамтран ашиглах маш цөөн тохиолдол байна гэж УСНББОУСЗ үзсэн. Иймээс энэ Стандартад корпорацийн хөрөнгийг тодорхойлох ба түүний шаардлагуудыг тогтоох шаардлагагүй гэж шийдвэрлэсэн. Бусад хөрөнгөөс хамааралгүй байдлаар мөнгөн гүйлгээ бий болгодоггүй бөгөөд мөнгө бий болгогч нэгээс олон нэгжийн бүрэлдэхүүн хэсэг болдог боловч мөнгө бий болгодоггүй үйл ажиллагаанд өөрийн үйлчилгээний чадавхиар хувь нэмрээ оруулдаггүй хөрөнгүүдийг тайлагнахдаа олон улсын болон үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартуудыг тухайн байгууллага харгалзахыг 96-р параграфт заасан байдаг.

*Мөнгө бий болгогч нэгжүүд дэх мөнгө бий болгодоггүй хөрөнгүүдийн тайлагнал*

ДҮ16. Улсын секторын байгууллагууд нь мөнгө бий болгодоггүй үйл ажиллагаанаас гадна МББН-үүдэд үйлчилгээний чадавхиараа хувь нэмрээ оруулдаг тийм мөнгө бий болгодоггүй хөрөнгүүдийг эзэмшдэг олон тохиолдол байх магадлалтай юм. УСНББОУСЗ нь МББН-үүд дэх ийм мөнгө бий болгодоггүй хөрөнгүүдийн тайлагналын арга хандлагыг авч үзсэн. Тухайлбал; МББН-ийн дансны үнийг түүний нөхөгдөх дүнтэй зэрэгцүүлэх үедээ УСНББОУС 21-ийн дагуу аливаа үнэ цэнийн бууралтын сорилыг хийсний дараах, мөнгө бий болгодоггүй хөрөнгийн дансны үнийн хэсгийг уг МББН-ийн дансны үнэд тусган оруулах нь зохистой эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн.

ДҮ17. УСНББОУСЗ нь ийм мөнгө бий болгодоггүй хөрөнгийн дансны үнийн хэсгийг уг МББН-ийн дансны үнэд тусган оруулах хэрэгтэй гэж дүгнэсэн. Тухайн МББН-д хувь нэмрээ оруулж буй ийм хөрөнгийн үйлчилгээний чадавхитай хувь тэнцүүлсэн сууриар энэхүү хувь хэсгийг тодорхойлдог. Хэрэв мөнгө бий болгодоггүй хөрөнгийг харгалзан үзэхгүй бол тухайн МББН-ийн дансны үнийг дутуу илэрхийлэх ба үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөхгүй байж болох юм. Гэвч мөнгө бий болгодоггүй хөрөнгийн аливаа үнэ цэнийн бууралтыг УСНББОУС 21-ийн дагуу тодорхойлдог учраас уг мөнгө бий болгодоггүй хөрөнгийг түүний нөхөгдөх үйлчилгээний дүн хүртэл бууруулна. Ингэснээр тухайн МББН-тэй холбоотой цаашдын үнэ цэнийн бууралтын гарзыг уг мөнгө бий болгодоггүй хөрөнгөнд хамааруулахгүй юм. 92-р параграфт заасан хязгаарлалтаас бусад тохиолдолд аливаа үнэ цэнийн бууралтын гарзыг МББН дэх мөнгө бий болгогч хөрөнгүүдэд тэдгээрийн дансны үнэд үндэслэн хувь тэнцүүлэн хуваарилна. Энэхүү арга хандлагыг 95-р параграфт заасан.

#### **2008 онд гаргасан, НББОУСЗ-ийн СТОУС-ын Сайжруулалтууд-ын үр дүнд УСНББОУС 26-д хийсэн хянан засварлалт**

ДҮ18. УСНББОУСЗ нь 2008 оны 5 дугаар сард НББОУСЗ-өөс гаргасан СТОУС-ын Сайжруулалтууд-д тусгасан, НББОУС 36-гийн хянан засварлалтыг нягталж шалгаад уг Стандартыг хянан засварлах болсон НББОУСЗ-ийн учир шалтгаантай ерөнхийдөө санал нийлсэн. УСНББОУСЗ нь уг нэмэлт

өөрчлөлтүүдийг мөрдөхгүй байх улсын секторын тусгай учир шалтгаан байхгүй гэж дүгнэсэн.

**УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд-ын Хэсэг II: “Санал гаргагчдын дэвшүүлсэн асуудлууд”-ын үр дүнд УСНББОУС 26-д хийсэн хянан засварлалт**

ДҮ19. Санал гаргагчид нь борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба данснаас хасах бүлгийг УСНББОУС тууштай бус илэрхийлсэн гэж үзсэн. СТОУС 5, *Борлуулах Зорилгоор Эзэмшиж Буй Эргэлтийн Бус Хөрөнгө ба Зогсоосон Үйл Ажиллагаа* нь дараах учир шалтгааны улмаас зөвхөн зарим нөхцөл байдалд улсын секторт тохиромжтой байж болох юм гэж УСНББОУС3 дүгнэсэн:

- (а) Шаардлагатай түвшний зөвшөөрлийн улмаас улсын секторт хөрөнгийн борлуулалтыг нэг жилийн дотор хийж чадахгүй байж болох юм. Энэ нь СТОУС 5-ын дагуу тусгах мэдээллийн хамааралтай ба тууштай байдалд эргэлзээ үүсгэдэг. Тухайлбал; борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийг СТОУС 5-ын дагуу элэгдүүлэхгүй гэдгийг УСНББОУС3 онцлон тэмдэглэсэн. Хөрөнгийг урт хугацаанд элэгдүүлэхгүй байх нь тохиромжгүй гэж УСНББОУС3 үзэж байна.
- (б) Улсын секторт олон хөрөнгийг үнэгүй эсвэл нэрлэсэн төлбөртэйгээр шилжүүлэх буюу түгээн хуваарилах замаар данснаас хасдаг. СТОУС 5 нь бодит үнэ цэнээр хийх борлуулалтыг авч үздэг тул түүний хэмжилт ба тодруулгын шаардлагууд нь ийм шилжүүлэлтийн хувьд холбогдох мэдээллээр хангадаггүй. Гэвч борлуулалтыг бодит үнэ цэнээр хийх санаа зорилготой байх тохиолдолд СТОУС 5-ын хэмжилт ба тодруулгын шаардлагууд нь тохиромжтой байж болно гэдгийг УСНББОУС3 хүлээн зөвшөөрдөг.
- (в) Улсын сектор дахь зогсоосон олон үйл ажиллагаа нь үнэгүй эсвэл нэрлэсэн төлбөртэйгээр өмнө үзүүлсэн үйлчилгээ байдаг. СТОУС 5 нь данснаас хасах эсвэл борлуулах зорилгоор эзэмшиж буй гэж дахин ангилахаас өмнө мөнгө бий болгогч нэгжүүд буюу мөнгө бий болгогч нэгжүүдийн бүлэг байсан, тийм зогсоосон үйл ажиллагааг авч үздэг тул түүний тодруулгын шаардлагууд нь улсын секторын зогсоосон үйл ажиллагааны хувьд холбогдох мэдээллээр хангадаггүй байж болох юм. Гэвч зогсоосон үйл ажиллагаа нь өмнө нь мөнгө бий болгогч нэгжүүд буюу мөнгө бий болгогч нэгжүүдийн нэг болон хэд хэдэн бүлгүүд байсан бол СТОУС 5-ын тодруулгын шаардлагууд тохиромжтой байж болно гэдгийг УСНББОУС3 хүлээн зөвшөөрдөг.

СТОУС 5 нь зөвхөн цөөн хязгаарлагдмал нөхцөл байдалд улсын секторт тохиромжтой гэж УСНББОУС3 дүгнэсэн учраас борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагааг авч үзэх олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн стандартуудын талаархи УСНББОУС дахь хэллэг лавлагааг хасахыг УСНББОУС3

зөвшөөрсөн. Ийм хэллэг лавлагааг хасалгүй үлдээх нь СТОУС 5-ын шаардлагууд тохиромжгүй байж болох нөхцөл байдалд байгууллагууд түүний шаардлагуудыг даган мөрдөхөд хүргэнэ гэж УСНББОУСЗ санаа зовж байсан. УСНББОУС-уудад тусгайлан авч үзээгүй ажил гүйлгээний хувьд нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох заавар удирдамжаар УСНББОУС 3 хангана гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Тохиромжтой гэж тухайн байгууллага үзсэн тохиолдолд СТОУС 5-тай нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тэдгээр байгууллагууд баримтлахыг ийм заавар удирдамжаар зөвшөөрсөн байдаг.

**2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУСЗ-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 26-д хийсэн хянан засварлалт**

ДҮ20. УСНББОУСЗ нь 2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт нэмэлт өөрчлөлт оруулсан:


- (a) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р* параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

## Үлгэрчилсэн шийдвэрийн мод

Энэхүү шийдвэрийн мод нь УСНББОУС 26-г дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

Хялбарчлах ба тодорхой болгох үүднээс МББН-ийн нэг хэсэг болох аливаа хөрөнгө нь мөнгө бий болгодоггүй үйл ажиллагаанд мөн өөрийн үйлчилгээний чадавхиар хувь нэмрээ оруулдаг гэж энэхүү блок схемд төсөөлсөн болно. Хөрөнгө нь мөнгө бий болгодоггүй үйл ажиллагаанд биш, зөвхөн нэг буюу хэд хэдэн МББН-үүдэд өөрийн үйлчилгээний чадавхиар хувь нэмрээ оруулдаг тохиолдолд байгууллага нь ийм нөхцөл байдлыг 96-р параграфын дагуу тайлагнахдаа олон улсын болон үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартуудыг харгалзан үзнэ.





## **Хэрэгжүүлэх заавар удирдамж**

*Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 26-г дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

*Улсын секторын байгууллагуудын эзэмшдэг ихэнх хөрөнгө нь мөнгө бий болгодоггүй хөрөнгө байдаг бөгөөд тэдгээрийн үнэ цэнийн бууралтын тайлагналыг УСНББОУС 21-ийн дагуу хийвэл зохино.*

*Улсын секторын байгууллагын хөрөнгийг арилжааны үр өгөөж бий болгох зорилготойгоор эзэмшдэг тийм тохиолдолд энэхүү Стандартын заалтуудыг баримтална. Ихэнх мөнгө бий болгогч хөрөнгүүд нь улсын секторын худалдаа арилжааны байгууллагуудын эрхлэн явуулдаг бизнесийн үйл ажиллагааны явцад үүсдэг. Жишээлбэл; хөдөө аж ахуйн судалгааны байгууллагын нэг хэсэг болох үр тариалах нэгж нь арилжааны сууриар үйл ажиллагаагаа явуулдаг.*

*Эдгээр бүх жишээний хувьд улсын секторын байгууллага нь арилжааны үйл ажиллагаа явуулдаг гэж үзнэ.*

## **Мөнгө бий болгогч нэгжийг тогтоох**

*Энэхүү жишээ нь дараах зорилготой:*

- (а) *янз бүрийн нөхцөл байдалд мөнгө бий болгогч нэгжүүдийг хэрхэн тогтоохыг харуулах; ба*
- (б) *хөрөнгийн харъяалагдах мөнгө бий болгогч нэгжийг тогтоохдоо тухайн байгууллагын харгалзан үзэж болох зарим хүчин зүйлсийг онцлон тэмдэглэх.*

## **А – Нэг бүтээгдэхүүн бүхий нэгжтэй холбоотой эрэлтийн бууралт**

### *Танилцуулга*

**ХЗУ1.** Засгийн газар нь цахилгаан үйлдвэрлэх нэгжтэй. Уг нэгж нь цахилгааны нэг үйлдвэртээ хоёр цахилгаан үүсгүүртэй. Тайлант үед тухайн бүс нутаг дахь гол үйлдвэр хаагдаж, цахилгаан эрчим хүчний эрэлт мэдэгдэхүйц буурсан. Үүний хариуд Засгийн газар нь нэг үүсгүүрийн үйл ажиллагааг зогсоосон.

### *Шинжилгээ*

**ХЗУ2.** Цахилгаан үүсгүүрүүд нь дангаараа мөнгөн орлогыг бий болгодоггүй. Иймээс үнэ цэнийн бууралтыг тодорхойлоход ашиглах мөнгө бий болгогч нэгж нь бүхэлдээ уг цахилгааны үйлдвэр байна.

## **Б – Засгийн газрын агаарын тээврийн нэгж, энэ нь онгоц түрээслүүлдэг**

### *Танилцуулга*

ХЗУ3. “М” нь Засгийн газрын байгууллагын агаарын тээврийн нэгж юм. Энэ нь гурван онгоц, нислэгийн зурвас, хэд хэдэн ангаар (онгоц зогсох саравч) ба бусад барилга байгууламжийг, үүн дотроо засвар үйлчилгээний болон түлш цэнэглэх төхөөрөмжийг эрхлэн ажиллуулдаг. Түүний үйлчилгээний эрэлт буурсан учраас “М” нэгж нь нэг онгоцоо хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид таван жилийн хугацаатай түрээслүүлсэн. Түрээсийн нөхцлийн дагуу “М” нэгж нь нислэгийн зурвасыг уг түрээслэгч ашиглахыг зөвшөөрсөн бөгөөд онгоцны бүх засвар үйлчилгээг хариуцна.

### *Шинжилгээ*

ХЗУ4. Түрээсийн нөхцлийн улмаас уг түрээслэсэн онгоцыг бүхэлдээ “М” нэгжийн мөнгөн орлогын гүйлгээнээс бүрэн хамааралгүй байдлаар мөнгөн орлогыг бий болгоно гэж үзэх боломжгүй болсон. Иймээс уг онгоцны харъяалагдах мөнгө бий болгогч нэгж нь бүхэлдээ “М” нэгж байх магадлалтай юм.

## **В – Хог хаягдал зайлуулах байгууллагын бутлуурын үйлдвэр**

### *Танилцуулга*

ХЗУ5. Хотын захиргаа нь хог хаягдал зайлуулах байгууллагыг эрхлэн ажиллуулдаг. Уг байгууллага нь өөрийн хог хаягдал зайлуулах үйл ажиллагааг дэмжих бутлуурын үйлдвэрийг өмчилдөг. Бутлуурын үйлдвэрийг зөвхөн устгалтын үнэ цэнээр борлуулж чадах бөгөөд энэ нь уг хог хаягдал зайлуулах байгууллагын бусад хөрөнгүүдийн мөнгөн орлогын гүйлгээнээс бүрэн хамааралгүй байдлаар мөнгөн орлогыг бий болгодоггүй.

ХЗУ6. Бутлуурын үйлдвэрийн ашиглалтын үнэ цэнийг тодорхойлж чадахгүй бөгөөд тэр нь устгалтын үнэ цэнээс өөр байх нилээд магадлалтай учраас түүний нөхөгдөх дүнг тооцоолох боломжгүй байна. Иймээс байгууллага нь уг бутлуурын үйлдвэрийн харъяалагдах мөнгө бий болгогч нэгжийн өөрөөр хэлбэл, бүхэлдээ хог хаягдал зайлуулах байгууллагын хувьд нөхөгдөх дүнг тооцоолно.

## **Г – Автобусны компанийн үзүүлэх тээврийн үйлчилгээ**

### *Танилцуулга*

ХЗУ7. Улсын автобусны компани нь хотын захиргааатай байгуулсан гэрээний дагуу үйлчилгээ үзүүлдэг бөгөөд уг гэрээнд таван тусдаа чиглэлийн замаар наад захын үйлчилгээг үзүүлэхээр заасан. Замын чиглэл тус бүрд хамаарах хөрөнгө болон олох мөнгөн орлогыг тусад нь

## МӨНГӨ БИЙ БОЛГОГЧ ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

тодорхойлж чадна. Нэг чиглэлийн зам нь мэдэгдэхүйц хэмжээний алдагдалтай ажилладаг.

### *Шинжилгээ*

ХЗУ8. Уг байгууллага нь автобусны аль нэг чиглэлийг зогсоох сонголт хийж чадахгүй учраас бусад хөрөнгө буюу хөрөнгүүдийн бүлгийн мөнгөн орлогын гүйлгээнээс бүрэн хамааралгүй, тодорхойлж болох мөнгөн орлогын гүйлгээний хамгийн доод түвшин нь тухайн таван чиглэлийн хамтдаа бий болгох мөнгөн орлого байна. Өөрөөр хэлбэл, мөнгө бий болгогч нэгж нь бүхэлдээ уг автобусны компани юм.

### **Ашиглалтын үнэ цэнийн тооцоолол ба үнэ цэнийн бууралтын гарзны хүлээн зөвшөөрөлт**

#### *Танилцуулга ба ашиглалтын үнэ цэнийн тооцоолол*

ХЗУ9. 20X0 оны эхэнд “R” засгийн газар нь өөрийн Эрчим хүчний хэлтсээр дамжуулан эрчим хүчний үйлдвэрийг ашиглалтанд оруулсан бөгөөд үүнийг 250 сая ТН-ээр барьсан.

ХЗУ10. 20X4 оны эхэнд өрсөлдөгчийн барьсан эрчим хүчний үйлдвэр ашиглалтанд орсноор “R” засгийн газрын эрчим хүчний үйлдвэрийн орлого нь буурахаар болсон. Үйлдвэрлэх эрчим хүчний хэмжээ хүлээгдэж байснаас буурсан, мөн эрчим хүчний үнэ болон хүчин чадлын хэмжээ нь хүлээгдэж байснаас буурсаны улмаас орлогын бууралт гарсан.

ХЗУ11. Уг орлогын бууралт нь тухайн хөрөнгийн эдийн засгийн гүйцэтгэл хүлээгдэж байснаас муу байгаагийн нотолгоо юм. Иймээс “R” засгийн газар нь уг хөрөнгийн нөхөгдөх дүнг тодорхойлох шаардлагатай болсон.

ХЗУ12. “R” засгийн газар нь эрчим хүчний үйлдвэрийн хувьд 20-н жилийн ашиглалтын хугацаанд элэгдлийн шулуун шугамын аргыг хэрэглэдэг бөгөөд үлдэх өртөггүй гэж урьдчилан таамагладаг.

ХЗУ13. Эрчим хүчний үйлдвэрийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийг тодорхойлох боломжгүй байна. Иймээс зөвхөн ашиглалтын үнэ цэнийн тооцооллоор нөхөгдөх байдлыг тодорхойлж болох юм. Эрчим хүчний үйлдвэрийн ашиглалтын үнэ цэнийг тодорхойлохын тулд (Хүснэгт 1-ийг үзнэ үү), “R” засгийн газар нь:

- (а) Удирдлагын баталсан дараагийн таван жилийн (20X5 оноос 20X9 оны) хамгийн сүүлийн үеийн санхүүгийн төсөв/прогнозад үндэслэн мөнгөн гүйлгээний төсөвлөлтийг бэлтгэх;
- (б) Жилд хасах (-) 6-аас хасах 3 хувиар бууруулсан өсөлтийн түвшинд үндэслэн дараагийн (20Y0 оноос 20Y9 оны) мөнгөн гүйлгээг тооцоолох; ба

МӨНГӨ БИЙ БОЛГОГЧ ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

- (в) Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон “R” засгийн газрын эрчим хүчний үйлдвэрт тусгайлан хамаарах эрсдлийн одоогийн зах зээлийн үнэлгээг тусган илэрхийлэх 6 хувийн дискаунтын түвшинг сонгох.

*Үнэ цэнийн бууралтын гарзын хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт*

ХЗУ14. “R” засгийн газрын эрчим хүчний үйлдвэрийн нөхөгдөх дүн нь 121.1 сая ТН байна.

ХЗУ15. “R” засгийн газар нь эрчим хүчний үйлдвэрийн нөхөгдөх дүнг түүний дансны үнэтэй зэрэгцүүлэн үзсэн (Хүснэгт 2-ыг үзнэ үү).

ХЗУ16. Дансны үнэ нь түүний нөхөгдөх дүнгээс 78.9 сая ТН-ээр илүү байгаа учраас уг 78.9 сая ТН-ийн үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдалд нэн даруй хүлээн зөвшөөрнө.

**Хүснэгт 1 – “R” засгийн газрын эрчим хүчний үйлдвэрийн 20X4 оны эцэс дэх ашиглалтын үнэ цэнийн тооцоолол**

Жил	Урт хугацааны өсөлтийн түвшин	Ирээдүйн мөнгөн гүйлгээ	6% дискаунтын түвшнээр тооцсон өнөөгийн үнэ цэнийн фактор <sup>§</sup>	Дискаунтчилсан ирээдүйн мөнгөн гүйлгээ (Сая ТН)
20X5 (n=1)		16.8*	0.94340	15.8
20X6		14.4*	0.89000	12.8
20X7		14.2*	0.83962	11.9
20X8		14.1*	0.79209	11.2
20X9		13.9*	0.74726	10.4
20Y0	(6%)	13.1†	0.70496	9.2
20Y1	(6%)	12.3†	0.66506	8.2
20Y2	(6%)	11.6†	0.62741	7.3
20Y3	(5%)	11.0†	0.59190	6.5
20Y4	(5%)	10.5†	0.55839	5.9
20Y5	(5%)	10.0†	0.52679	5.3
20Y6	(4%)	9.6†	0.49697	4.8
20Y7	(4%)	9.2†	0.46884	4.3
20Y8	(3%)	8.9†	0.44230	3.9
20Y9	(3%)	8.6†	0.41727	3.6
<b>Ашиглалтын үнэ цэнэ</b>				<b>121.1</b>

\* Цэвэр мөнгөн гүйлгээний талаархи удирдлагын хамгийн сайн тооцоололд үндэслэсэн.

† Буурах өсөлтийн түвшинг ашиглан өмнөх жилийн мөнгөн гүйлгээнээс экстраполяциар тооцсон дүнд үндэслэсэн.

§  $k=1/1(+a)^n$  гэж тооцоолсон өнөөгийн үнэ цэнийн фактор. Энд a=дискаунтын түвшин, n=дискаунтын үеийн тоо.

**Хүснэгт 2 – “R” засгийн газрын эрчим хүчний үйлдвэрийн 20X5 оны эхэн дэх үнэ цэнийн бууралтын гарзын тооцоолол**

<b>20X5 оны эхэнд</b>	<b>Дүн (Сая ТН)</b>
Түүхэн өртөг	250.0
Хуримтлагдсан элэгдэл (20X4)	(50.0)
Дансны үнэ	200.0
Үнэ цэнийн бууралтын гарзын дараах дансны үнэ	121.1
Үнэ цэнийн бууралтын гарз	(78.9)

**Үнэ цэнийн бууралтын гарзын буцаалт**

*Энэхүү жишээ нь түүнд дурдсан нэмэлт мэдээллээс гадна Жишээ 2-д толилуулсан “R” засгийн газрын мэдээнд үндэслэсэн. Энэ жишээнд татварын үр нөлөөг харгалзан үзээгүй.*

*Танилцуулга*

ХЗУ17. 20X6 онд зарим өрсөлдөгч нар нь өөрсдийн эрчим хүчний үйлдвэрүүдийг хаасан бөгөөд энэ нь “R” засгийн газрын 2004 оны эцэст төсөвлөж байсан, түүний орлогод үзүүлэх сөрөг нөлөө багассан гэсэн утгыг илэрхийлнэ. Энэхүү тааламжтай өөрчлөлт нь эрчим хүчний үйлдвэрийнхээ нөхөгдөх дүнг дахин тооцоолохыг тус засгийн газраас шаардсан.

ХЗУ18. Жишээ 2-д дурдсантай ижил тооцоолол нь уг эрчим хүчний үйлдвэрийн нөхөгдөх дүн одоо 157.7 сая ТН болсон гэдгийг харуулж байна.

*Үнэ цэнийн бууралтын гарзын буцаалт*

ХЗУ19. “R” засгийн газар нь эрчим хүчний үйлдвэрийн нөхөгдөх дүн ба цэвэр дансны үнийг зэрэгцүүлэн үзсэн бөгөөд Жишээ 2-д өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзын зарим хэсгийг буцаасан.

**Мөнгө бий болгогч нэгжид хувь нэмрээ оруулдаг мөнгө бий болгодоггүй хөрөнгө**

*Танилцуулга*

ХЗУ20. Улсын эмнэлэг нь Соронзон Долгионт Дүрс Оношилгоо (СДДО)-ны төхөөрөмжийг өмчилж, ажиллуулдаг бөгөөд төлбөргүй хэвтэн эмчлүүлэгчдийн тасагт түүнийг ихэвчлэн ашигладаг. Гэвч төлбөртэй хэвтэн эмчлүүлэгчдийн эмчилгээнд түүний хүчин чадлын 20 хувийг ашигладаг. Төлбөртэй эмчлүүлэгч нар нь тусдаа барилгад хэвтэн эмчлүүлдэг. Уг барилга нь зөвхөн төлбөртэй эмчлүүлэгчдэд зориулсан тасаг, мэс заслын өрөө болон олон тооны капитал тоног төхөөрөмжүүдтэй. 20X6 оны 12 дугаар сарын 31-нд уг барилгын болон капитал тоног төхөөрөмжийн дансны үнэ 30,000ТН байсан. Барилга болон тоног төхөөрөмжийн нөхөгдөх дүнг хөрөнгө тус бүрээр тооцоолох

боломжгүй юм. Иймээс барилга болон тоног төхөөрөмжийг хамтад нь, мөнгө бий болгогч нэгж (МББН) гэж үздэг. 20Х6 оны 01 дүгээр сарын 01-нд СДДО-ны төхөөрөмж нь 3,000ТН-ийн дансны үнэтэй байсан. 20Х6 оны 12 дугаар сарын 31-нээр уг СДДО-ны төхөөрөмжийн хувьд 600ТН-ийн элэгдлийн зардал хүлээн зөвшөөрсөн. Тухайн талбарт технологийн мэдэгдэхүйц дэвшил гарсан учраас СДДО-ны төхөөрөмжийн үнэ цэнийн бууралтыг 20Х6 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар сорьж шалгасан бөгөөд 20Х6 оны 12 дугаар сарын 31-нд түүний дансны үнийг 2,000ТН болгохын тулд 400ТН-ийн үнэ цэнийн бууралтын гарз тодорхойлсон.

*Мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүнгийн тодорхойлолт*

ХЗУ21. Тайлант жилд тус эмнэлгийн төлбөртэй хэвтэн эмчлүүлэгчдийн тоо мэдэгдэхүйц буурсан. Иймээс МББН-ийн үнэ цэнийн бууралтын сорьж шалгасан. Уг МББН-ийн ашиглалтын үнэ цэнэд үндэслэсэн нөхөгдөх дүнг 27,400ТН гэж үнэлсэн. Энэхүү үнэ цэнийн бууралтын гарзыг (3,000ТН) тодорхойлохын өмнө тус СДДО-ны төхөөрөмжийн хянан засварласан дансны үнийн 20 хувийг (400ТН) энэхүү МББН-ийн дансны үнэд хуваарилсан. Үнэ цэнийн бууралтын гарзыг барилга болон тоног төхөөрөмжинд тэдгээрийн дансны үнэд үндэслэн хувь тэнцүүлэн хуваарилсан. УСНББОУС 21, “Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт”-ын шаардлагуудын дагуу үнэ цэнийн бууралтын гарзыг нь нэгэнт тодорхойлсон тул уг СДДО-ны төхөөрөмжинд цаашид үнэ цэнийн бууралтын гарз хуваарилахгүй юм.

**Хүлээн зөвшөөрсөн өр төлбөрийг мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүнгийн тооцоололд оруулах**

*Танилцуулга*

ХЗУ22. Хотын захиргаа нь хог хаягдал зайлуулах талбарыг эрхлэн ажиллуулдаг бөгөөд түүний үйл ажиллагаа дууссаны дараа уг талбарыг нөхөн сэргээх шаардлагатай. Энэхүү нөхөн сэргээлтийн зардал нь уг хог хаягдал зайлуулах үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө хуулж авах шаардлагатай өнгөн хөрсийг нөхөн сэргээх зардлыг багтаасан байдаг. Өнгөн хөрсийг нөхөн сэргээх өртөг зардлын нөөцийг тэрхүү өнгөн хөрсийг хуулсан даруйд хүлээн зөвшөөрдөг. Энэхүү тооцоолсон дүнг тухайн талбарын өртгийн нэг хэсэг байдлаар хүлээн зөвшөөрсөн бөгөөд уг талбарын ашиглалтын хугацааны туршид элэгдүүлнэ. Нөхөн сэргээлтийн зардлын нөөцийн дансны үнэ нь уг нөхөн сэргээлтийн зардлын өнөөгийн үнэ цэнэтэй тэнцүү буюу 500ТН байна.

*Үнэ цэнийн бууралтын сорил*

ХЗУ23. Хотын захиргаа нь тус талбарын үнэ цэнийн бууралтыг сорьж шалгаж байна. Мөнгө бий болгогч нэгж нь бүхэлдээ уг талбар юм. Засгийн газар нь уг талбарыг 800ТН-ээр худалдан авах янз бүрийн саналыг хүлээн авсан. Энэ үнэ нь өнгөн хөрсийг нөхөн сэргээх үүргийг тухайн худалдан авагч хүлээнэ гэсэн нөхцлийг тусгасан. Тухайн талбарыг данснаас хасах

зардал нь өчүүхэн бага байна. Тус талбарын ашиглалтын үнэ цэнэ нь ойролцоогоор 1,200ТН бөгөөд үүнд нөхөн сэргээлтийн зардал ороогүй болно. Хог хаягдал зайлуулах талбарын дансны үнэ нь 1,000ТН байна.

ХЗУ24. Мөнгө бий болгогч нэгжийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ нь 800ТН юм. Энэ дүнд өмнө бүрдүүлсэн нөхөн сэргээлтийн зардал багтаж байна. Иймээс нөхөн сэргээлтийн зардлыг харгалзсаны дараах байдлаар уг мөнгө бий болгогч нэгжийн ашиглалтын үнэ цэнийг тодорхойлж, түүнийг 700ТН (1,200ТН-ээс 500ТН-ийг хасах) гэж тооцоолсон. Уг мөнгө бий болгогч нэгжийн дансны үнэ нь талбарын дансны үнэ (1,000ТН)-ээс нөхөн сэргээлтийн зардлын нөөцийн дансны үнэ (500ТН)-ийг хассан дүн буюу 500ТН болно. Иймээс мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүн нь түүний дансны үнээс илүү байна.

### **Данснаас хасах үйл ажиллагааны дансны үнэд гүүдвилийг оруулах**

#### *Танилцуулга*

ХЗУ24А. Гүүдвилийг хуваарилсан уг мөнгө бий болгогч нэгжийн нэг хэсэг болох үйл ажиллагааг хотын захиргаа нь 100ТН-ээр борлуулсан. Тухайн нэгжид хуваарилсан гүүдвилийг санамсаргүй тохиолдлын шинжтэй хуваарилахаас бусад тохиолдолд уг нэгжээс доод түвшний хөрөнгийн бүлэгт хамааруулах буюу хуваарилах боломжгүй байна. Уг мөнгө бий болгогч нэгжийн үлдэх хэсгийн нөхөгдөх дүн нь 300ТН байна.

#### *Нягтлан бодох бүртгэлийн хандлага*

ХЗУ24Б. Мөнгө бий болгогч нэгжид хуваарилсан гүүдвилийг тухайн нэгжээс доод түвшний хөрөнгийн бүлэгт санамсаргүй тохиолдлын шинжтэйгээс өөр бусад сууриар хамааруулах буюу хуваарилж чадахгүй учраас уг данснаас хассан үйл ажиллагаа болон тухайн нэгжийн үлдсэн хэсгийн харьцангуй үнэ цэнүүдэд үндэслэн тэрхүү данснаас хассан үйл ажиллагаатай холбоотой гүүдвилийг хэмжинэ. Иймээс мөнгө бий болгогч нэгжид хуваарилсан гүүдвилийн 25 хувийг тухайн худалдан борлуулсан үйл ажиллагааны дансны үнэд хамааруулан оруулна.

### **Мөнгө бий болгогч нэгжийн бүтцийг өөрчилсөн үед гүүдвилийг дахин хуваарилах**

#### *Танилцуулга*

ХЗУ24В. Гүүдвилийг мөнгө бий болгогч нэгж А-д өмнө нь хуваарилсан. А-д хуваарилсан уг гүүдвилийг санамсаргүй тохиолдлын шинжтэйгээс өөр бусад сууриар А-аас доод түвшний хөрөнгийн бүлэгт хамааруулах буюу хуваарилж чадахгүй. А нь задран хуваагдаж, Б, В, Г гэсэн мөнгө бий болгогч өөр гурван нэгжид нэгтгэгдсэн.

*Нягтлан бодох бүртгэлийн хандлага*

ХЗУ24Г. А-д хуваарилсан гүүдвилийг санамсаргүй тохиолдлын шинжтэйгээс өөр бусад сууриар А-гаас доод түвшний хөрөнгийн бүлэгт хамааруулах буюу хуваарилж чадахгүй тул Б, В, Г-д нэгтгэхийн өмнөх А-гийн тэдгээр гурван хэсгийн харьцангуй үнэ цэнэд үндэслэн гүүдвилийг Б, В, Г нэгжүүдэд дахин хуваарилна.

**Нөхөгдөх дүнг тодорхойлж чадах эсэхээс хамаарах, мөнгө бий болгогч нэгж дэх тусдаа хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн хандлага**

*Танилцуулга*

ХЗУ25. Ус цэвэршүүлэх үйлдвэрийн ус хадгалах саванд биет гэмтэл гарсан бөгөөд гэмтлийн өмнөх шиг сайн биш боловч ажилласаар байгаа. Ус хадгалах савны борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ нь түүний дансны үнээс бага байна. Уг ус хадгалах сав нь бусад хөрөнгөөс хамааралгүй байдлаар мөнгөн орлогын гүйлгээ бий болгодоггүй. Тухайн ус хадгалах савыг агуулсан бөгөөд бусад хөрөнгийн мөнгөн орлогоос бүрэн хамааралгүй байдлаар мөнгөн орлогыг бий болгох хөрөнгүүдийн тодорхойлж болох хамгийн бага бүлэг нь уг ус хадгалах савны харъяалагдах үйлдвэрийн цех юм. Энэхүү үйлдвэрийн цехийн нөхөгдөх дүн нь бүхэлдээ уг цех үнэ цэнийн бууралтанд ороогүй гэдгийг харуулж байна.

*Ус хадгалах савны нөхөгдөх дүнг тодорхойлж чадахгүй байх*

ХЗУ26. Таамаглал 1: Удирдлагын баталсан төсөв/прогноз нь уг ус хадгалах савыг сольж орлуулах удирдлагын хариуцлагыг тусгаагүй байх.

ХЗУ27. Ус хадгалах савны ашиглалтын үнэ цэнэ нь:

- (а) түүний борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээс өөр байж болох; ба
- (б) тухайн ус хадгалах савны харъяалагдах мөнгө бий болгогч нэгжийн (ус цэвэршүүлэх үйлдвэрийн цехийн) хувьд зөвхөн тодорхойлогдох боломжтой

тул түүний нөхөгдөх дүнг дангаар нь тооцоолж чадахгүй юм. Иймээс ус хадгалах савны хувьд үнэ цэнийн бууралтын гарз хүлээн зөвшөөрөхгүй. Гэвч байгууллага нь уг ус хадгалах савны хувьд элэгдлийн хугацаа буюу элэгдэл тооцох аргыг дахин авч үзэх шаардлагатай байж болно. Магадгүй, уг ус хадгалах савны хүлээгдэж буй ашиглалтын үлдсэн хугацаа эсвэл эдийн засгийн өгөөжийг тухайн байгууллага ашиглан зарцуулахаар хүлээгдэж буй төлөв байдлыг тусгахын тулд элэгдлийн хугацааг багасгах болон хурдавчилсан элэгдлийн аргыг хэрэглэх шаардлагатай болж болох юм.



*Ус хадгалах савны нөхөгдөх дүнг тодорхойлж чадах*

ХЗУ28. Таамаглал 2: Удирдлагын баталсан төсөв/прогноз нь уг ус хадгалах савыг сольж орлуулах буюу ойрын ирээдүйд худалдан борлуулах удирдлагын хариуцлагыг тусгасан байх. Ус хадгалах савыг данснаас хасах хүртэлх тасралтгүй ашиглалтаас үүсэх мөнгөн гүйлгээ нь өчүүхэн бага гэж тооцоолсон.

ХЗУ29. Ус хадгалах савны ашиглалтын үнэ цэнийг түүний борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэтэй ойролцоогоор тооцоолж чадна. Иймээс ус хадгалах савны нөхөгдөх дүнг тодорхойлж болох бөгөөд уг ус хадгалах савны харъяалагдах мөнгө бий болгогч нэгжийг (өөрөөр хэлбэл, үйлдвэрийн цехийг) харгалзан үзэхгүй. Ус хадгалах савны борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ нь түүний дансны үнээс бага тул уг ус хадгалах савны хувьд үнэ цэнийн бууралтын гарз хүлээн зөвшөөрнө.

## НББОУС 36-ТАЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт* нь улсын секторын мөнгө бий болгогч хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралтыг авч үздэг бөгөөд 2008 оны 5 дугаар сард гаргасан, *СТОУС-ын Сайжруулалтууд*-ын нэг хэсэг байдлаар НББОУС 36, *Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг үүнд тусгасан болно. УСНББОУС 26 ба НББОУС 36-гийн хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- УСНББОУС 17, *Үндсэн Хөрөнгө*-д заасан, дахин үнэлгээний загварын дагуу тухайн тайлангийн өдрөөр дахин үнэлсэн дүнгээр бүртгэдэг мөнгө бий болгогч хөрөнгийн хувьд УСНББОУС 26-г мөрддөггүй. Харин НББОУС 36 нь тухайн тайлангийн өдрөөр дахин үнэлсэн дүнгээр бүртгэсэн мөнгө бий болгогч үндсэн хөрөнгийг өөрийн цар хүрээнээс хасдаггүй.
- Бодит үнэ цэнээр нь байнга дахин үнэлдэг биет бус хөрөнгийн хувьд УСНББОУС 26-г мөрдөхгүй. Харин НББОУС 36 нь бодит үнэ цэнээр байнга дахин үнэлдэг биет бус хөрөнгийг өөрийн цар хүрээнээс хасдаггүй.
- УСНББОУС 26 нь мөнгө бий болгогч хөрөнгийг тодорхойлж, мөнгө бий болгогч хөрөнгө ба мөнгө бий болгодоггүй хөрөнгүүдийг ялган зааглах нэмэлт тайлбарыг тусган оруулсан.
- УСНББОУС 26 дахь мөнгө бий болгогч нэгжийн тодорхойлолтыг НББОУС 36-гаас авч, тохируулан хэрэглэсэн болно.
- УСНББОУС 26 нь корпорацийн хөрөнгийн тодорхойлолт буюу ийм хөрөнгөтэй холбоотой шаардлагуудыг тусгаагүй. НББОУС 36 нь корпорацийн хөрөнгийн тодорхойлолт, тэдгээрийн тайлагналын шаардлагууд болон заавар удирдамжийг агуулсан байдаг.
- УСНББОУС 26 нь байгууллагын цэвэр хөрөнгийн дансны үнэ түүний зах зээлийн капиталжуулалтын дүнгээс илүү байхыг үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг гэж үздэггүй. НББОУС 36 нь байгууллагын цэвэр хөрөнгийн дансны үнэ түүний зах зээлийн капиталжуулалтын дүнгээс илүү байхыг үнэ цэнийн бууралтын хамгийн наад захын цогц шинж тэмдгийн нэг хэсэг гэж үздэг.
- УСНББОУС 26-д зааснаар, албадан борлуулалт нь борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн тусгал биш юм. Хэрэв удирдлага нь нэн даруй борлуулах шахалт шаардлагад орсон бол НББОУС 36-д зааснаар, албадан борлуулалт нь борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн тусгал мөн гэж үздэг.
- УСНББОУС 26 нь мөнгө бий болгогч нэгжүүдэд, түүнчлэн мөнгө бий болгодоггүй үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулдаг мөнгө бий болгодоггүй хөрөнгүүдийн тайлагналын талаархи шаардлагууд болон заавар удирдамжийг агуулсан байдаг. НББОУС 36 нь мөнгө бий болгогч

нэгжүүдэд, түүнчлэн мөнгө бий болгодоггүй үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулдаг мөнгө бий болгодоггүй хөрөнгүүдийг авч үздэггүй.

- УСНББОУС 26 нь мөнгө бий болгогч хөрөнгөөс мөнгө бий болгодоггүй хөрөнгө эсвэл мөнгө бий болгодоггүй хөрөнгөөс мөнгө бий болгогч хөрөнгө болгон дахин ангилахтай холбогдсон шаардлагууд болон заавар удирдамжийг агуулсан байдаг. Мөн УСНББОУС 26 нь мөнгө бий болгогч хөрөнгийг мөнгө бий болгодоггүй хөрөнгөөс ялган зааглахын тулд боловсруулсан шалгуураа тодруулахыг байгууллагуудаас шаарддаг. НББОУС 36-д үүнтэй адилтгах шаардлага байдаггүй.
- УСНББОУС 26 нь зарим тохиолдолд НББОУС 36-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь “орлого” /revenue/, “санхүүгийн үр дүнгийн тайлан” гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. НББОУС 36 дахь адилтгах нэр томъёо нь “орлого” /income/, “орлогын тайлан” юм.

## УСНББОУС 27–ХӨДӨӨ АЖ АХУЙ

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) 41, *Хөдөө Аж Ахуй*-гаас үндсэндээ бэлтгэсэн болно. НББОУС 41-ээс авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон EC4M 6ХН, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)

Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.

## УСНББОУС 27-ХӨДӨӨ АЖ АХУЙ

### УСНББОУС-ын түүх

Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

УСНББОУС 27, Хөдөө Аж Ахуй-г 2009 оны 12 дугаар сард гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 27-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл (2017 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2011-ийн Сайжруулалтууд (2011 оны 10 дугаар сард гаргасан)

### УСНББОУС 27-гийн нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт

Өөрчлөгдсөн параграф	Хэрхэн өөрчилсөн	Юугаар өөрчилсөн
Танилцуулга хэсэг	Хассан	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
2	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
3	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
5	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
6	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
7	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
8	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
9	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
9А	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар

ХӨДӨӨ АЖ АХУЙ

9Б	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
9В	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
13	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
28	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
34	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
40	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
48	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
55	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
56А	Шинэ	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
56Б	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
56В	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
56Г	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
56Д	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
56Е	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
57	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар

**УСНББОУС 27–ХӨДӨӨ АЖ АХУЙ**

**АГУУЛГА**

---

	Параграф
Зорилго	1
Цар хүрээ	2-8
Тодорхойлолт	9-12
Хөдөө аж ахуйтай холбоотой тодорхойлолтууд	9-11
Ерөнхий тодорхойлолт	12
Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт	13-37
Олз ба гарз	30-33
Бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй байдал	34-37
Тодруулга	38-54
Ерөнхий зүйл	38-51
Бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжих боломжгүй биологийн хөрөнгийн нэмэлт тодруулга	52-54
Шилжилтийн нөхцөл	55
Аккруэл нягтлан бодох бүртгэлийг анх удаа мөрдөх	55
Хүчин төгөлдөр болох хугацаа	56-57
Хавсралт: Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт	
Дүгнэлтийн үндэслэл	
Үлгэрчилсэн жишээ	
НББОУС 41-тэй харьцуулалт	

## ХӨДӨӨ АЖ АХУЙ

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 27, Хөдөө Аж Ахуй-г 1-57-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 27-г түүний зорилгын агуулга, Дүгнэлтийн Үндэслэл, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.



## Зорилго

1. Энэхүү Стандартын зорилго нь хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой нягтлан бодох бүртгэлийн арга хандлага болон тодруулгыг тодорхойлоход оршино.

## Цар хүрээ

2. **Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь дараах зүйлс хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой байх тохиолдолд тэдгээрийн тайлагналд энэхүү Стандартыг мөрдөнө:**
  - (а) **Эх ургамлаас бусад биологийн хөрөнгө;**
  - (б) **Үр шим хүртэх үеийн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн;**
3. Энэ Стандартыг дараах зүйлсэд мөрдөхгүй:
  - (а) Хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой газар (УСНББОУС 16, *Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө* ба УСНББОУС 17, *Үндсэн Хөрөнгө*-ийг үзнэ үү).
  - (б) Хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой эх ургамал (УСНББОУС 17-г үзнэ үү). Гэхдээ энэ Стандартыг тэдгээр эх ургамлын бүтээгдэхүүний хувьд мөрдөнө.
  - (в) Хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой биет бус хөрөнгө (УСНББОУС 31, *Биет Бус Хөрөнгө*-ийг үзнэ үү).
  - (г) Үйлчилгээ үзүүлэх буюу нийлүүлэх зорилгоор эзэмшиж буй биологийн хөрөнгө.
4. Улсын секторын байгууллагуудын эрхлэн явуулдаг олон үйл ажиллагаанд биологийн хөрөнгийг ашигладаг. Энэ Стандартын 9-р параграфт тодорхойлсон, хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд хамаарахгүй судалгаа шинжилгээ, боловсрол, тээвэр, баяр ёслол, амралт сувилал, гаалийн хяналт зэрэг бусад аливаа үйл ажиллагаанд биологийн хөрөнгийг ашигласан тохиолдолд тэдгээр биологийн хөрөнгийг энэ Стандартын дагуу тайлагнахгүй. Тэдгээр биологийн хөрөнгө нь хөрөнгийн тодорхойлолтыг хангадаг бол зохих нягтлан бодох бүртгэлийг тодорхойлохын тулд бусад УСНББОУС-ыг (жишээлбэл; УСНББОУС 12, *Бараа Материал* ба УСНББОУС 17-г) харгалзан үзвэл зохино.
5. Үр шим хүртэх үед тухайн байгууллагын биологийн хөрөнгөөс хүлээн авсан бүтээгдэхүүн болох хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хувьд энэхүү Стандартыг мөрдөнө. Харин үр шим хүртсэнээс хойшхи үед УСНББОУС 12, *Бараа Материал* эсвэл бусад холбогдох Стандартыг мөрдөнө. Иймээс үр шим хүртсэний дараах хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтыг, жишээлбэл; усан үзэм тарьж ургуулдаг дарсны худалдаачин нь уг усан үзмээрээ дарс хийх үйл явцыг энэ Стандартад авч үзэхгүй. Ийм боловсруулалт нь хөдөө аж ахуйн үйл ажиллагааны логик

## ХӨДӨӨ АЖ АХУЙ

үндэслэлтэй, хэвийн үргэлжлэл бөгөөд хийгдэж буй үйл явц нь биологийн хувьсал өөрчлөлттэй зарим талаар ижил төсөөтэй шинж чанартай байж болох боловч уг боловсруулалтыг энэ Стандарт дахь хөдөө аж ахуйн үйл ажиллагааны тодорхойлолтонд хамруулахгүй.

6. Биологийн хөрөнгө, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, үр шим хүртсэний дараах боловсруулалтын үр дүн болох бүтээгдэхүүний жишээг дараах хүснэгтэнд харуулав:

Биологийн хөрөнгө	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн	Үр шим хүртсэний дараах боловсруулалтын үр дүн болох бүтээгдэхүүн
Хонь	Ноос	Ээрсэн утас, хивс
Таримал мод	Тайрсан мод	Гуалин, банз
Сүүний чиглэлийн үнээ	Сүү	Бяслаг
Гахай	Мах	Хиам зайдас, утсан мах
Хөвөнгийн ургамал	Хураасан хөвөн	Утас, хөвөн даавуу
Чихрийн нишинг мод	Хураасан нишингэ	Элсэн чихэр
Тамхины ургамал	Хураасан навч	Хатаасан тамхи
Цайны ургамал	Хураасан навч	Цай
Усан үзмийн бут	Хураасан усан үзэм	Дарс
Жимсний мод	Түүсэн жимс	Боловсруулсан жимс
Тослог далдуу мод	Түүсэн жимс	Далдуу модны тос
Каучукны мод	Каучукнаас хураасан сүүн шүүс	Каучукан бүтээгдэхүүн

Зарим ургамал, тухайлбал, цайны ургамал, усан үзмийн бут, тослог далдуу мод, каучукны мод зэрэг нь эх ургамлын тодорхойлолтыг ихэвчлэн хангадаг бөгөөд УСНББОУС 17-гийн цар хүрээнд хамаарна. Харин эх ургамлаас авдаг бүтээгдэхүүн, жишээлбэл, цайны навч, усан үзэм, далдуу модны жимс, каучукны шүүс нь УСНББОУС 27-гийн цар хүрээнд хамаарна.

7. [Хассан]

8. [Хассан]

## Тодорхойлолт

### Хөдөө аж ахуйтай холбоотой тодорхойлолтууд

9. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

**Хөдөө аж ахуйн үйл ажиллагаа** гэдэг нь байгууллага дараах зорилгоор биологийн хувьсал болон биологийн хөрөнгөөс үр шим хүртэлтийг удирдан явуулах үйл ажиллагаа юм:

## ХӨДӨӨ АЖ АХУЙ

- Борлуулах;
- Үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилах; эсвэл
- Борлуулах эсвэл үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилахын тулд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн буюу нэмэлт биологийн хөрөнгө болгон хувиргах.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн гэдэг нь тухайн байгууллагын биологийн хөрөнгөөс хүлээн авсан бүтээгдэхүүн юм.

Эх ургамал гэдэг нь дараах амьд ургамлыг хэлнэ:

- (a) Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл буюу нийлүүлэлтэнд ашиглагдах;
- (б) Нэгээс олон тайлант үед бүтээгдэхүүн өгөхөөр хүлээгдэж байгаа;
- (в) Тохиолдлын шинжтэй хаягдлын борлуулалтаас бусад тохиолдолд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн байдлаар борлуулах магадлал багатай.

Биологийн хөрөнгө гэдэг нь амьд амьтан буюу ургамал юм.

Биологийн хувьсал гэдэг нь биологийн хөрөнгөнд тоон буюу чанарын өөрчлөлт гарахад хүргэх өсөлт, хөгшрөлт, үйлдвэрлэл, нөхөн үржлийн үйл явц юм.

Борлуулах зардал гэдэг нь хөрөнгийн данснаас хасалтанд шууд хамаарах өсөн нэмэгдсэн зардал бөгөөд үүнд санхүүгийн зардал ба орлогын татварын зардал хамаарахгүй.

Биологийн хөрөнгүүдийн бүлэг гэдэг нь амьд, ижил төсөөтэй ургамал буюу амьтны нэгдэл юм.

Үр шим хүртэлт гэдэг нь биологийн хөрөнгөөс бүтээгдэхүүнийг салган авалт эсвэл биологийн хөрөнгийн амьдрах үйл явцын зогсоолт юм.

9А. Дараах зүйлс нь эх ургамал биш юм:

- (a) Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн байдлаар хураан авахын тулд тарьж ургуулдаг ургамал (жишээлбэл; банз болгож ашиглахын тулд ургуулсан мод);
- (б) Байгууллага нь тухайн ургамлыг тохиолдлын шинжтэй хаягдлын борлуулалт байдлаар биш, харин хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн хэлбэрээр хураан авч, борлуулах нь бага бус магадлалтай тохиолдолд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг бий болгохын тулд тарьж ургуулсан ургамал (жишээлбэл; үр жимсийг авах ба банз болгон ашиглахын тулд тарьж ургуулсан мод);

## ХӨДӨӨ АЖ АХУЙ

- (в) Нэг наст ургамал (жишээлбэл; эрдэнэ шиш, улаан буудай).
- 9Б. Цаашид бүтээгдэхүүн авах зорилгоор эх ургамлыг ашиглахаа больсон тохиолдолд түүнийг тайрч, хаягдал жишээлбэл; түлээний мод байдлаар борлуулж болно. Ийм тохиолдлын шинжтэй хаягдлын борлуулалт нь уг ургамал эх ургамлын тодорхойлолтыг хангахад саад учруулахгүй юм.
- 9В. Эх ургамлаас ургаж буй бүтээгдэхүүн нь биологийн хөрөнгө юм.
10. Хөдөө аж ахуйн үйл ажиллагаа нь маш олон төрлийн үйл ажиллагааг хамардаг. Үүнд: мал аж ахуй, ойн аж ахуй, нэг наст буюу олон наст ургамал тариалалт, жимс болон мод бут тарих, цэцгийн аж ахуй, усны амьтан болон ургамал үржүүлэлт (үүн дотроо загасны аж ахуй) хамаарна. Энэхүү олон төрлийн үйл ажиллагаанд зарим нийтлэг шинжүүд байдаг:
- (а) *Өөрчлөгдөх чадвар*. Амьд амьтан, ургамал нь биологийн хувьсалд орох чадвартай байдаг;
- (б) *Өөрчлөлтийн удирдлага*. Удирдлага нь тухайн үйл явц явагдахад зайлшгүй шаардлагатай нөхцлийг (тухайлбал, тэжээлийн түвшин, ус чийг, дулаан, үржил шим, гэрэл гэх мэт) сайжруулснаар эсвэл наад зах нь тогтвортой байлгаснаар биологийн хувьсалд дэмжлэг үзүүлдэг. Ийм удирдлага нь хөдөө аж ахуйн үйл ажиллагааг бусад үйл ажиллагаанаас ялгаж өгдөг. Тухайлбал; удирдан зохицуулдаггүй нөөцөөс үр шим хүртэх (далайгаас загас барих, ойгоос мод огтлох гэх мэт) нь хөдөө аж ахуйн үйл ажиллагаа биш юм;
- (в) *Өөрчлөлтийн хэмжилт*. Биологийн хувьсалаар эсвэл үр шим хүртсэнээр үүссэн чанарын (жишээлбэл; генетик шинж, нягт, болц, өөх тарга, уургийн агууламж, эд эсийн бат бөх байдал) буюу тоон өөрчлөлтийг (жишээлбэл; үр төл, жин, эзлэхүүн, эд эсийн урт, диаметр, нахианы тоо) удирдлагын хэвийн үйл ажиллагаа байдлаар хэмжиж, хянан зохицуулна.
11. Биологийн хувьслаар дараах үр дүн гардаг:
- (а) Хөрөнгө нь (i) өсөлт (ургамал, амьтны тоо хэмжээний өсөлт эсвэл чанарын сайжралт) (ii) хөгшрөлт (ургамал, амьтны тоо хэмжээний бууралт эсвэл чанарын доройтолт), (iii) нөхөн үржил (амьд амьтан, ургамал нэмж бий болох)-ийн үр дүнд өөрчлөгдөх; эсвэл
- (б) Ургамлын шүүс, цайны навч, ноос, сүү гэх мэт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн бий болох.

### Ерөнхий тодорхойлолт

12. **Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь-д дахин нийтэлсэн болно.**

## Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

13. **Байгууллага нь биологийн хөрөнгө эсвэл хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг зөвхөн дараах тохиолдолд хүлээн зөвшөөрнө:**
  - (а) **Байгууллага нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд тухайн хөрөнгийг хянадаг;**
  - (б) **Уг хөрөнгөтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхи нь тухайн байгууллагад орох магадлалтай; ба**
  - (в) **Уг хөрөнгийн бодит үнэ цэнэ эсвэл өртгийг найдвартай<sup>1</sup> хэмжиж чадах.**
14. Хөрөнгийн бодит үнэ цэнэ нь түүний одоогийн байршил ба нөхцөл байдалд үндэслэдэг. Иймээс тухайлбал, фермерийн аж ахуй дахь бод малын бодит үнэ цэнэ нь холбогдох зах зээлд тухайн малыг борлуулах үнээс түүнийг уг зах зээл рүү эсвэл үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилах тийм байршилд тээвэрлэх болон авчрах бусад зардлыг хассан дүн байна.
15. Хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд, тухайлбал, бод малын хувьд түүний хууль ёсны өмчлөх эрхээр болон худалдан авах, төллөх, эхээс тусгаарлах үед малд им тавих буюу бусад байдлаар тэмдэглэснээр хяналтыг нотолж болно. Биологийн хөрөнгийн гол биет шинжүүдийг хэмжсэнээр түүний ирээдүйн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг ихэвчлэн үнэлдэг.
16. **34-р параграфт заасан, бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй нөхцөл байдлаас бусад тохиолдолд биологийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхөд болон тайлант үе бүрийн эцэст түүний борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээр нь хэмжинэ.**
17. **Байгууллага нь биологийн хөрөнгийг арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн тохиолдолд уг биологийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхөд болон тайлант үе бүрийн эцэст 16-р параграфын дагуу хэмжинэ.**
18. **Тухайн байгууллагын биологийн хөрөнгөөс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг үр шим хүртэх үед борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээр хэмжинэ. Ийм хэмжилт нь УСНББОУС 2, *Бараа Материал* буюу бусад холбогдох Стандартыг мөрдөх өдрөөрх өртөг болно.**

---

<sup>1</sup> Найдвартай мэдээлэл нь материаллаг алдаа ба туйлшралаас ангид байх бөгөөд өөрийн илэрхийлэхээр зориулагдсан буюу илэрхийлнэ гэж ул үндэслэлтэйгээр хүлээж болох зүйлсийг үнэн зөв илэрхийлэхдээ хэрэглэгчдээс хамаардаг байж болох юм. Найдвартай байдлын тайлбарын талаархи шилжилтийн арга хандлагыг УСНББОУС 1-ийн ДҮ16-р параграфт авч хэлэлцсэн.

## ХӨДӨӨ АЖ АХУЙ

19. Биологийн хөрөнгө болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг тэдгээрийн гол шинжүүдээр, тухайлбал нас, чанараар бүлэглэх нь биологийн хөрөнгө буюу хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бодит үнэ цэнийн хэмжилтийг хялбарчилж өгдөг. Үнэ тогтоох суурь болгон зах зээлд ашигладаг шинжүүдийг харгалзан уг байгууллага нь дээрх шинжүүдийг сонгодог.
20. Байгууллага нь өөрийн биологийн хөрөнгө буюу хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг ирээдүйд борлуулах гэрээг ихэвчлэн байгуулдаг. Бодит үнэ цэнэ нь зах зээлд оролцогч худалдан авагч ба борлуулагч нар ажил гүйлгээг хийх одоогийн зах зээлийн нөхцөл байдлыг тусгадаг тул гэрээний үнэ нь бодит үнэ цэнийн хэмжилттэй заавал холбоотой байх албагүй юм. Иймээс байгуулсан гэрээтэй холбоотойгоор биологийн хөрөнгө буюу хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бодит үнэ цэнийг тохируулахгүй. Зарим тохиолдолд биологийн хөрөнгө буюу хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг арилжааны ажил гүйлгээгээр борлуулах гэрээ нь УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-д заасан, алдагдалтай гэрээ байж болох юм. Алдагдалтай гэрээний хувьд УСНББОУС 19-ийг мөрдөнө.
21. Одоогийн байршил болон нөхцөл байдалд байгаа биологийн хөрөнгө буюу хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хувьд идэвхитэй зах зээл оршин байгаа бол уг зах зээлийн жишиг үнэ нь тухайн хөрөнгийн бодит үнэ цэнийг тодорхойлох зохих суурь үндэслэл болно. Хэрэв байгууллага нь идэвхитэй янз бүрийн зах зээлд оролцдог бол хамгийн их хамааралтай зах зээлийн үнийг сонгож ашиглана. Жишээлбэл; байгууллага нь идэвхитэй хоёр зах зээлд оролцдог бол тухайн ашиглахаар хүлээгдэж буй зах зээлд оршин байгаа үнийг ашиглах юм.
22. Хэрэв идэвхитэй зах зээл оршин байхгүй бол бодит үнэ цэнийг тодорхойлохдоо байгууллага нь бэлэн боломжтой байгаа дараах нэг буюу хэд хэдэн зүйлсийг ашиглана:
  - (а) Уг ажил гүйлгээний өдөр ба тухайн тайлангийн өдрийн хоорондох хугацаанд эдийн засгийн нөхцөл байдалд мэдэгдэхүйц өөрчлөлт ороогүй бол тэрхүү зах зээлийн хамгийн сүүлийн ажил гүйлгээний үнэ;
  - (б) Ижил төсөөтэй хөрөнгийн ялгаатай талуудыг тусгах тохируулгын хамтаар уг ижил төсөөтэй хөрөнгийн зах зээлийн үнэ;
  - (в) Экспортын нэг таваг, бушель<sup>2</sup> эсвэл гектар жимсний үнээр илэрхийлэгдэх жимсний аж ахуйн үнэ цэнэ, нэг килограмм махны үнээр илэрхийлэгдэх бод малын үнэ цэнэ гэх мэт салбарын бенчмарк.
23. Зарим тохиолдолд 22-р параграфт жагсаан харуулсан мэдээллийн эх сурвалжууд нь биологийн хөрөнгө буюу хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бодит үнэ цэнийн хувьд зөрүүтэй дүгнэлтүүдийг илэрхийлж болох юм.

<sup>2</sup> Bushel-Бушель гэдэг нь АНУ-д хэрэглэдэг эзлэхүүний хэмжүүр бөгөөд 35.2391 литртэй тэнцүү байдаг. Ред.Ч.Д.

## ХӨДӨӨ АЖ АХУЙ

Байгууллага нь ул үндэслэлтэй тооцооллын харьцангуй хязгаарлагдмал мужийн дотор бодит үнэ цэнийн хамгийн найдвартай тооцоололд хүрэхийн тулд уг зөрүүтэй байдлын учир шалтгааныг харгалзан үздэг.

24. Зарим тохиолдолд зах зээлээр тодорхойлсон үнэ буюу үнэ цэнүүд нь биологийн хөрөнгийн одоогийн нөхцөл байдалд бэлэн боломжтой байхгүй байж болох юм. Ийм тохиолдолд бодит үнэ цэнийг тодорхойлохдоо байгууллага нь тухайн хөрөнгөөс олохоор хүлээгдэж буй цэвэр мөнгөн гүйлгээний одоогийн зах зээлийн хүүний түвшнээр дискаунтчилсан өнөөгийн үнэ цэнийг ашигладаг.
25. Хүлээгдэж буй цэвэр мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийн тооцооллын зорилго нь биологийн хөрөнгийн бодит үнэ цэнийг түүний одоогийн байршил ба нөхцөл байдалд тодорхойлох явдал юм. Байгууллага нь хүлээгдэж буй цэвэр мөнгөн гүйлгээг тооцоолохдоо ашиглах зохих дискаунтын түвшинг тодорхойлохдоо үүнийг харгалзан үздэг. Хүлээгдэж буй цэвэр мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийг тодорхойлохдоо, байгууллага нь түүний хамгийн их хамааралтай зах зээлд тухайн хөрөнгөөс бий болгохоор уг зах зээлийн оролцогчдын хүлээж буй цэвэр мөнгөн гүйлгээг харгалзан тусгадаг.
26. Байгууллага нь тухайн хөрөнгийг санхүүжүүлэх, татвар төлөх эсвэл үр шим хүртэлтийн дараа биологийн хөрөнгийг нөхөн сэргээх (жишээлбэл; үр шим хүртсэний дараа таримал ойд дахин мод суулгах зардал) аливаа мөнгөн зарлагыг энэхүү мөнгөн гүйлгээний тооцоололд оруулахгүй.
27. Харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээний үнийг зөвшин тохирохдоо, зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа худалдан авагч ба борлуулагч нар нь мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлтийн боломжит байдлыг харгалзан үздэг. Эндээс уг бодит үнэ цэнэ нь ийм хувьсан өөрчлөлтийн боломжит байдлыг тусгасан гэж дүгнэдэг. Иймээс байгууллага нь мөнгөн гүйлгээний боломжит хувьсан өөрчлөлтийн талаархи хүлээлтүүдийг тухайн хүлээгдэж буй мөнгөн гүйлгээнд эсвэл дискаунтын түвшинд эсвэл эдгээрийн зарим нэгтгэн хослуулалтанд харгалзан оруулдаг. Дисканутын түвшинг тодорхойлохдоо, байгууллага нь зарим таамаглалын үр нөлөөг давхар тооцох эсвэл орхигдуулахаас зайлсхийхийн тулд уг хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг тооцоолоход ашигласан таамаглалуудтай нийцэх тийм таамаглалуудыг ашигладаг.
28. Өртөг нь зарим үед ялангуяа дараах тохиолдолд бодит үнэ цэнэтэй ойролцоо байж болох юм:
  - (а) Анхны өртөг гарснаас хойш биологийн хувьсал бага явагдсан байх (жишээлбэл; тайлант үеийн эцсээс дөнгөж өмнөхөн суулгасан үрслэг эсвэл шинээр худалдаж авсан мал амьтны хувьд); эсвэл
  - (б) Үнэд үзүүлэх биологийн хувьслын үр нөлөө нь материаллаг бус байх (жишээлбэл; 30 жилийн настай тариалсан шилмүүст модны эхний ургалт, өсөлт).

29. Биологийн хөрөнгө нь газартай ямагт биетээр холбоотой байдаг (жишээлбэл; таримал ой дахь мод). Газартай салшгүй холбоотой биологийн хөрөнгийн хувьд тусдаа зах зээл байдаггүй боловч нэгтгэсэн хөрөнгүүд, өөрөөр хэлбэл биологийн хөрөнгө, сайжруулалт хийгдээгүй газар, газрын сайжруулалтыг багцлан авч үзвэл түүнд хамаарах идэвхитэй зах зээл оршин байж болох юм. Байгууллага нь биологийн хөрөнгийн бодит үнэ цэнийг хэмжихийн тулд тухайн нэгтгэсэн хөрөнгүүдийн талаархи мэдээллийг ашиглаж болно. Жишээлбэл; биологийн хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцохын тулд сайжруулалт хийгдээгүй газар болон газрын сайжруулалтын бодит үнэ цэнийг тухайн нэгтгэсэн хөрөнгүүдийн бодит үнэ цэнээс хасаж болох юм.

### **Олз ба гарз**

30. **Биологийн хөрөнгийг түүний борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээр анх хүлээн зөвшөөрөлтөөс, түүнчлэн уг биологийн хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс бий болох олз буюу гарзыг тэдгээрийн үүссэн тухайн тайлант үеийн ашиг, алдагдалд тусгана.**
31. Биологийн хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийг тодорхойлохдоо борлуулах зардлыг хасдаг учраас биологийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтөөр гарз үүсэж болох юм. Мөн биологийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтөөр олз үүсэж болно. Жишээлбэл; үнээ тугалж, төл хүлээн авах үед.
32. **Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг түүний борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээр анх хүлээн зөвшөөрөлтийн олз, гарзыг үүссэн тухайн тайлант үеийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.**
33. Үр шим хүртэлтийн үр дүн байдлаар хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг анх хүлээн зөвшөөрөх үед олз, гарз үүсэж болох юм.

### **Бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй байдал**

34. Биологийн хөрөнгийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадна гэсэн урьдчилсан нөхцөл байдаг. Гэвч зах зээлийн жишиг үнэ бэлэн байхгүй бөгөөд бодит үнэ цэнийн өөр хувилбар хэмжилтүүд нь илт найдваргүй гэдгийг тодорхойлсон, биологийн хөрөнгийг зөвхөн анх хүлээн зөвшөөрөх үед энэхүү урьдчилсан нөхцлийг няцааж болно. Ийм тохиолдолд биологийн хөрөнгийг түүний өртгөөс аливаа хуримтлагдсан элэгдэл ба аливаа хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр хэмжинэ. Ийм биологийн хөрөнгийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжтой болмогц байгууллага нь уг хөрөнгийг түүний борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээр хэмжинэ.
35. 34-р параграфт дурдсан, урьдчилсан нөхцлийг зөвхөн анхны хүлээн зөвшөөрөлтийн үед няцааж болно. Биологийн хөрөнгийг түүний борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээр өмнө нь хэмжиж байсан



## ХӨДӨӨ АЖ АХУЙ

байгууллага нь тухайн биологийн хөрөнгийг данснаас хасах хүртэл түүний борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээр хэмжсэн хэвээр байна.

36. Бүх тохиолдолд байгууллага нь үр шим хүртэх үед хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг түүний борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээр хэмжинэ. Энэхүү Стандарт нь үр шим хүртэх үед хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бодит үнэ цэнийг ямагт найдвартай хэмжиж чадна гэсэн үзэл баримтлалыг тусгадаг.
37. Өртөг, хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг тодорхойлохдоо, байгууллага нь УСНББОУС 2, УСНББОУС 17, УСНББОУС 21, *Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*, УСНББОУС 26, *Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-ыг харгалзан үзнэ.

## Тодруулга

### Ерөнхий зүйл

38. **Байгууллага нь биологийн хөрөнгө ба хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний анх хүлээн зөвшөөрөлтөөс, түүнчлэн биологийн хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс тухайн тайлант үеийн туршид үүссэн нийт олз, гарзыг тодруулна.**
39. **Байгууллага нь таваарын ба үржлийн биологийн хөрөнгийг хооронд нь, мөн борлуулах зорилгоор эзэмшиж буй биологийн хөрөнгө ба үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилах зорилгоор эзэмшиж буй биологийн хөрөнгийг хооронд нь ялган тодорхойлж, тэдгээр биологийн хөрөнгийн талаархи тайлбар тодорхойлолтыг бэлтгэнэ.**
40. Таваарын биологийн хөрөнгө гэдэг нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн хэлбэрээр хураан авах эсвэл биологийн хөрөнгө байдлаар борлуулах, үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө юм. Таваарын биологийн хөрөнгийн жишээ нь; мах бэлтгэлд зориулсан мал амьтад, борлуулах зорилгоор эзэмшиж байгаа мал амьтад, аж ахуйн зориулалттай загас, эрдэнэ шиш ба улаан буудай гэх мэт үр тариа, эх ургамлаас авсан бүтээгдэхүүн, банз бэлтгэх зорилгоор ургуулж буй мод гэх мэт нэг удаа ашиглах зориулалттай мал амьтад болон ургамал юм. Үржлийн биологийн хөрөнгө гэдэг нь хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд нэгээс олон жилийн хугацаанд дахин давтан буюу байнга тасралтгүй ашиглагдах биологийн хөрөнгө юм. Үржлийн биологийн хөрөнгө нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн биш боловч бүтээгдэхүүн нөхөн үйлдвэрлэн бий болгох зорилгоор түүнийг эзэмшдэг. Үржлийн биологийн хөрөнгө болох мал амьтадын төрлийн жишээнд үржүүлгийн амьтад (үүн дотроо, загас ба шувуу), сүүний чиглэлийн мал, ноос ноолуурын үйлдвэрлэлд ашиглах хонь буюу бусад мал амьтад хамаарна. Үржлийн биологийн хөрөнгө болох ургамлын төрлийн жишээнд жимс хураан авах

## ХӨДӨӨ АЖ АХУЙ

мод, түүнчлэн жимс, самар, ургамлын шүүс, модны давирхай, үйс, навчин бүтээгдэхүүн хураан авах зорилгоор тарьж ургуулсан усан үзмийн ороонго, бут сөөг зэрэг хамаарна.

41. 39-р параграфтаар шаардсан тодруулга нь тоон тайлбар тодорхойлолт хэлбэртэй байж болно. Уг тоон тайлбар тодорхойлолтонд хүүрнэсэн тайлбар хийж болох юм.
42. 39-р параграфтаар шаардсан тодруулгыг хийхдээ, байгууллага нь мөн нас бие гүйцсэн ба төл биологийн хөрөнгийг өөр хооронд нь ялгаж, тодруулахыг дэмжинэ. Эдгээр ангилан ялгалт нь ирээдүйн мөнгөн гүйлгээний болон үйлчилгээний чадавхийн хугацааг үнэлэхэд ач холбогдолтой байж болох мэдээллээр хангадаг. Байгууллага нь ийм аливаа ангилан ялгалт хийж буй суурийг тодруулна.
43. Нас бие гүйцсэн биологийн хөрөнгө гэдэг нь үр шимийг хураан авч болох тусгай шинжүүд бүрдсэн (таваарын биологийн хөрөнгийн хувьд), эсвэл хэвийн тогтмол үр шим өгөх боломжтой болсон (үржлийн биологийн хөрөнгийн хувьд) биологийн хөрөнгө юм.
44. **Санхүүгийн тайлангийн хамт хэвлэн нийтэлсэн мэдээллийн аль нэг хэсэгт тодруулаагүй бол байгууллага нь дараах зүйлсийг тодорхойлон тодруулна. Үүнд:**
  - (a) **Биологийн хөрөнгийн бүлэг тус бүртэй холбоотой түүний үйл ажиллагааны шинж төрөл;**
  - (б) **Дараах зүйлсийн биет тоо хэмжээний талаархи санхүүгийн бус хэмжилт буюу тооцоолол:**
    - (i) **Тухайн тайлант үеийн эцэс дэх уг байгууллагын биологийн хөрөнгийн бүлэг тус бүрийн;**
    - (ii) **Тухайн тайлант үеийн турш дахь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний гарц.**
45. **Байгууллага нь үр шим хүртэх үе дэх хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бүлэг нэг бүрийн болон биологийн хөрөнгийн бүлэг тус бүрийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо ашигласан аргууд болон таамаглалуудыг тодруулна.**
46. **Байгууллага нь тухайн тайлант үеийн туршид хураан авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний уг үр шим хүртэх үед тодорхойлсон, борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийг тодруулна.**
47. **Байгууллага нь дараах зүйлсийг тодруулна:**
  - (a) **Эрхийн хязгаарлалт хийгдсэн биологийн хөрөнгийн оршин байдал ба түүний дансны үнэ, түүнчлэн өр төлбөрийн баталгаа болгон барьцаалсан биологийн хөрөнгийн дансны үнэ;**

- (б) Биологийн хөрөнгийг ашиглах буюу борлуулах уг байгууллагын чадвар боломжинд тавигдах хязгаарлалтын шинж төрөл ба хэмжээ;
  - (в) Биологийн хөрөнгийг хөгжүүлэх эсвэл худалдан авах талаар хүлээсэн хариуцлагын дүн; ба
  - (г) Хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой санхүүгийн эрсдлийн удирдлагын стратеги.
48. Байгууллага нь тухайн тайлант үеийн эхэн ба эцсийн хооронд биологийн хөрөнгүүдийн дансны үнэд гарсан өөрчлөлтийн тохируулгын тайланг толилуулна. Тохируулгын тайланд дараах зүйлсийг тусгана:
- (а) Борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз буюу гарз, үүнийг үржлийн биологийн хөрөнгө ба таваарын биологийн хөрөнгийн хувьд тус тусад нь тодруулна;
  - (б) Худалдан авалтын үр дүнд нэмэгдсэн дүн;
  - (в) Арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн хөрөнгийн үр дүнд нэмэгдсэн дүн;
  - (г) Борлуулалтын үр дүнд буурсан дүн;
  - (д) Үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилсаны үр дүнд буурсан дүн;
  - (е) Үр шим хүртсэний үр дүнд буурсан дүн;
  - (ж) Улсын секторын нэгдлийн үр дүнд нэмэгдсэн дүн;
  - (и) Санхүүгийн тайланг толилуулгын өөр валютанд хөрвүүлснээр болон гадаад үйл ажиллагааг уг тайлагнагч байгууллагын толилуулгын валютанд хөрвүүлснээр үүссэн ханшийн цэвэр зөрүү; ба
  - (к) Бусад өөрчлөлтүүд.
49. Биологийн хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ нь биет өөрчлөлтийн болон зах зээлийн үнийн өөрчлөлтийн аль алины улмаас өөрчлөгдөж болно. Биет болон үнийн өөрчлөлтийн тусдаа тодруулга нь тухайн тайлант үеийн гүйцэтгэл ба ирээдүйн хэтийн төлөвийг үнэлэхэд, ялангуяа үйлдвэрлэлийн мөчлөг нэг жилээс урт хугацаатай байх үед ач холбогдолтой байдаг. Энэ тохиолдолд байгууллага нь биет өөрчлөлт болон үнийн өөрчлөлтийн улмаас үүссэн ба ашиг, алдагдалд тусгасан, борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн өөрчлөлтийн дүнг бүлэглэн эсвэл бусад байдлаар тодруулахыг дэмжинэ. Үйлдвэрлэлийн мөчлөг нэг жилээс богино хугацаатай байх тохиолдолд (жишээлбэл; тахиа үржүүлэх, үр тариа тарьж ургуулах) энэ мэдээлэл нь ерөнхийдөө ач холбогдол багатай байдаг.
50. Биологийн хувьсал нь өсөлт, хөгшрөлт, үйлдвэрлэл, нөхөн үржил гэсэн биет өөрчлөлтийн олон төрөл хэлбэрээр явагддаг бөгөөд эдгээрийг тус

## ХӨДӨӨ АЖ АХУЙ

бүрд нь ажиглаж, хэмжих боломжтой байдаг. Эдгээр биет өөрчлөлт нэг бүр нь ирээдүйн эдийн засгийн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхитай шууд харилцан холбоотой байдаг. Үр шим хүртсэний улмаас биологийн хөрөнгийн бодит үнэ цэнэд гарах өөрчлөлт нь мөн биет өөрчлөлт юм.

51. Хөдөө аж ахуйн үйл ажиллагаа нь цаг агаар, өвчин эмгэг болон байгалийн бусад эрсдэлд байнга өртөж байдаг. Материаллаг орлого эсвэл зардлын зүйл үүсэхэд хүргэх үйл явдал гарч тохиолдсон бол уг зүйлийн төрөл ба дүнг УСНББОУС 1-ийн дагуу тодруулна. Ийм үйл явдлын жишээнд гоц халдварт өвчний дэгдэлт, үер, ган гачиг, зуд, тахал зэрэг хамаарна.

**Бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжих боломжгүй биологийн хөрөнгийн нэмэлт тодруулга**

52. Хэрэв байгууллага нь тухайн тайлант үеийн эцэст биологийн хөрөнгийг түүний өртгөөс аливаа хуримтлагдсан элэгдэл ба аливаа хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр хэмждэг бол (34-р параграфыг үзнэ үү) уг байгууллага нь ийм биологийн хөрөнгийн хувьд дараах зүйлсийг тодруулна:

- (а) Биологийн хөрөнгийн тайлбар тодорхойлолт;
- (б) Бодит үнэ цэнийг нь яагаад найдвартай хэмжих боломжгүй талаархи тайлбар;
- (в) Хэрэв боломжтой бол бодит үнэ цэнэ нь харъяалагдах өндөр магадлалтай байгаа тооцооллын муж;
- (г) Ашигласан элэгдлийн арга;
- (д) Ашиглалтын хугацаа буюу ашигласан элэгдлийн хувь хэмжээ; ба
- (е) Тухайн тайлант үеийн эхэн ба эцэс дэх нийт дансны үнэ болон хуримтлагдсан элэгдэл (хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзтай нэгтгэн нийлүүлсэн).

53. Хэрэв байгууллага нь тухайн тайлант үеийн туршид биологийн хөрөнгийг түүний өртгөөс аливаа хуримтлагдсан элэгдэл ба аливаа хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр хэмждэг бол (34-р параграфыг үзнэ үү) уг байгууллага нь ийм биологийн хөрөнгийн данснаас хасалтаар хүлээн зөвшөөрсөн аливаа олз, гарзыг тодруулна, мөн 48-р параграфт заасан тохируулгын тайланд тухайн биологийн хөрөнгөнд хамаарах дүнгүүдийг тусад нь тодруулна. Түүнчлэн, уг тохируулга нь биологийн хөрөнгөтэй холбоотойгоор ашиг, алдагдалд тусгасан дараах дүнгүүдийг агуулсан байна:

- (а) Үнэ цэнийн бууралтын гарз;
- (б) Үнэ цэнийн бууралтын гарзын буцаалт; ба
- (в) Элэгдэл.

54. Өмнө нь өртгөөс аливаа хуримтлагдсан элэгдэл ба аливаа хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр хэмжсэн биологийн хөрөнгийн бодит үнэ цэнийг тухайн тайлант үеийн туршид найдвартайгаар хэмжих боломжтой болсон бол байгууллага нь уг биологийн хөрөнгийн хувьд дараах зүйлсийг тодруулна:
- (а) Биологийн хөрөнгийн тайлбар тодорхойлолт;
  - (б) Бодит үнэ цэнийг нь яагаад найдвартай хэмжих боломжтой талаархи тайлбар; ба
  - (в) Уг өөрчлөлтийн үр нөлөө.

### Шилжилтийн нөхцөл

55. [Хассан]

### Хүчин төгөлдөр болох хугацаа

56. Байгууллага нь энэхүү Стандартыг 2011 оны 4 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2011 оны 4 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 56А. 2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-ийн үр дүнд 55, 57-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед УСНББОУС 33-ыг мөрдсөн бол эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.
- 56Б. 2016 оны 4 дүгээр сард гаргасан УСНББОУС 2015-ын *Сайжруулалтууд*-аар 34, 48-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 56В. 2016 оны 4 дүгээр сард гаргасан УСНББОУС 2015-ын *Сайжруулалтууд*-аар 2, 3, 5, 6, 9, 28, 40-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулж, 9А, 9Б, 9В параграфуудыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2017 оны 01 дүгээр

- сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа*-ны дагуу буцаах горимоор мөрдөнө.
- 56Г. *УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд*-ын Хэсэг IV-ийн үр дүнд УСНББОУС 17 ба УСНББОУС 27-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг анх удаа мөрдсөн тайлант үедээ байгууллага нь УСНББОУС 3-ийн 33(е) параграфтаар шаардсан, тоон шинжтэй мэдээллийг уг одоогийн тайлант үеийн хувьд тодруулах шаардлагагүй юм. Гэвч УСНББОУС 3-ын 33(е) параграфтаар шаардсан тоон шинжтэй мэдээллийг байгууллага нь тухайн толилуулсан тайлант үе тус бүрд толилуулна.
- 56Д. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 7, 8-р параграфуудыг хассан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 56Е. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл*-ийн үр дүнд 48-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.
57. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

**Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт**

[Хассан]

## Дүгнэлтийн Үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 27-г дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### Оршил

- ДҮ1. УСНББОУС3-ийн СТОУС-тай нийцүүлэх хөтөлбөр нь УСНББОУС3-ийн ажлын хөтөлбөрийн чухал элемент юм. УСНББОУС3-ийн бодлого нь улсын секторын байгууллагуудад тохиромжтой тохиолдолд НББОУС3-өөс гаргасан СТОУС-тай аккруэл суурьт УСНББОУС-ыг нийцүүлэх явдал юм.
- ДҮ2. Улсын секторын хувьд гажих тусгай учир шалтгаан байхаас бусад тохиолдолд СТОУС-тай нийцүүлсэн, аккруэл суурьт УСНББОУС нь СТОУС-ын шаардлага, бүтэц, текстийг тэр хэвээр хадгална. СТОУС-ын шаардлага буюу нэр томъёо нь улсын секторт тохиромжгүй эсвэл улсын секторын хувьд зарим тодорхой шаардлагуудыг үлгэрчлэн харуулахын тулд нэмэлт тайлбар буюу жишээ оруулах шаардлагатай тохиолдолд адилтгах СТОУС-аас гаждаг. УСНББОУС-ууд ба тэдгээртэй адилтгах СТОУС-уудын хоорондох ялгаатай талуудыг УСНББОУС нэг бүрд тусган оруулсан *СТОУС-тай Харьцуулалт*-д тодорхойлсон.

### Үйлчилгээ үзүүлэх буюу нийлүүлэх зорилгоор эзэмшиж буй биологийн хөрөнгө

- ДҮ3. УСНББОУС3 нь улсын секторын хувьд биологийн хөрөнгийг ихэвчлэн үйлчилгээ үзүүлэх буюу нийлүүлэх зорилгоор эзэмшдэг гэж онцлон тэмдэглэсэн. Ийм биологийн хөрөнгийн жишээнд цагдаагийн байгууллагад ашиглаж буй морь ба нохой, амралт зугаалгын зорилгоор эрхлэн ажиллуулдаг парк, цэцэрлэгт хүрээлэн дэх ургамал ба мод хамааран. Ийм биологийн хөрөнгийг 10-р параграфт заасанчлан, биологийн хувьсал эсвэл үр шим хүртэлтийн улмаас түүний чанар болон тоо хэмжээнд орсон өөрчлөлтийг хэмжих ба хянан үнэлэх зорилгоор байнга удирдан зохицуулдаггүй учраас тэдгээрийг хөдөө аж ахуйн үйл ажиллагаанд ашиглах зорилгоор эзэмшдэггүй гэж УСНББОУС3 дүгнэсэн. Ийм биологийн хөрөнгүүдийг энэ Стандартад авч үзэхгүй гэдгийг тодруулахын тулд УСНББОУС3 нь үйлчилгээ үзүүлэх буюу нийлүүлэх зорилгоор эзэмшиж буй биологийн хөрөнгөнд энэ Стандартыг мөрдөхгүй гэдгийг илэрхийлсэн цар хүрээний хязгаарлалтыг 3(в) параграфт оруулахаар шийдвэрлэсэн. Ийм цар хүрээний хязгаарлалтын жишээг 4-р параграфт харуулсан.

### Хөдөө аж ахуйн үйл ажиллагааны тодорхойлолт

- ДҮ4. Зарим улс оронд, хөдөө аж ахуйн үйл ажиллагааны нэг хэсэг болох биологийн хөрөнгийг бусад улсын секторын байгууллага, төрийн бус байгууллага болон бусад байгууллагуудад борлуулж, эсвэл үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилж болох юм. Энэ Стандартыг үндэслэн бэлтгэсэн НББОУС 41, *Хөдөө Аж Ахуй* нь хөдөө аж ахуйн



арилжааны үйл ажиллагааг авч үздэг боловч биологийн хөрөнгийг үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилах ажил гүйлгээ нь улсын секторт нийтлэг байдаг тул ийм зорилгоор эзэмшиж буй биологийн хөрөнгө нь хөдөө аж ахуйн үйл ажиллагааны тодорхойлолтонд хамаарна гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Иймээс УСНББОУСЗ нь үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилах зорилгоор эзэмшиж буй биологийн хөрөнгийн талаархи заалтыг тусган оруулахын тулд НББОУС 41-ийн тодорхойлолтыг засварлан өөрчилж, хэрэглэсэн.

### **Засгийн газрын буцалтгүй тусламж**

ДҮ5. Биологийн хөрөнгөтэй холбоотой засгийн газрын буцалтгүй тусламжийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагууд болон заавар удирдамж нь НББОУС 20, *Засгийн Газрын Буцалтгүй Тусламжийн Нягтлан Бодох Бүртгэл ба Засгийн Газрын Туслалцааны Тодруулга*-д заасан шаардлагуудаас өөр гэдгийг НББОУС 41-д тусгайлан заасан. УСНББОУС 23, *Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Татвар ба Шилжүүлэг)* нь арилжааны бус ажил гүйлгээгээр үүссэн засгийн газрын буцалтгүй тусламжтай холбоотой шаардлагууд ба заавар удирдамжаар хангадаг учраас засгийн газрын буцалтгүй тусламжийн талаархи шаардлагууд болон заавар удирдамжийг УСНББОУС 27-д тусган оруулаагүй. Биологийн хөрөнгөтэй холбоотой засгийн газрын буцалтгүй тусламжийн нягтлан бодох бүртгэл нь УСНББОУС 23-ын шаардлагуудаас гажиж хэлбийнэ гэж УСНББОУСЗ үзэхгүй байна.

### **Арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн биологийн хөрөнгө ба хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн**

ДҮ6. Байгууллага нь биологийн хөрөнгө эсвэл хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшиж болох юм. Энэ Стандартын дагуу эдгээр хөрөнгүүдийг борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээр хэмждэг. УСНББОУС 23 нь арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн ийм хөрөнгүүдийг уг олж эзэмшсэн өдрөөрх тэдгээрийн бодит үнэ цэнээр анх хэмжих хэрэгтэй гэж заасан байдаг. Хэмжилтийн өөр өөр шаардлагуудын улмаас УСНББОУСЗ нь арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн биологийн хөрөнгөнд тохиромжтой хэмжилтийн суурийг авч үзсэн.

ДҮ7. УСНББОУСЗ нь арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн биологийн хөрөнгө болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг хэмжих янз бүрийн арга хандлагуудыг шүүмжлэн хэлэлцсэн. Тухайлбал; УСНББОУСЗ нь дараах гурван хандлагыг авч үзсэн:

- (a) Хандлага 1: Арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн бүх биологийн хөрөнгө ба хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг УСНББОУС 23-ыг ашиглан хэмжих (өөрөөр хэлбэл, арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн бүх биологийн хөрөнгө ба хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг энэ Стандартын хэмжилтийн шаардлагуудаас чөлөөлөх);

## ХӨДӨӨ АЖ АХУЙ

- (б) Хандлага 2: Арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн бүх биологийн хөрөнгө ба хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг энэ Стандартыг ашиглан хэмжих (өөрөөр хэлбэл, арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн бүх биологийн хөрөнгө ба хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг УСНББОУС 23-ын хэмжилтийн шаардлагуудаас чөлөөлөх);
- (в) Хандлага 3: Арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн биологийн хөрөнгө ба хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг хэмжихдээ УСНББОУС 23 болон энэ Стандартын аль алиныг ашиглах.

ДҮ8. Арилжааны болон арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн биологийн хөрөнгө ба хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг өөр өөр байдлаар хэмждэг тул УСНББОУС3 нь Хандлага 1-ээс татгалзсан. Арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн биологийн хөрөнгө ба хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн нь арилжааны ажил гүйлгээгээр олж эзэмшсэн ийм хөрөнгүүдтэй ижил учраас тэдгээрийг өөр өөр байдлаар хэмжих учир шалтгаан байхгүй гэдгийг УСНББОУС3 зөвшөөрсөн.

ДҮ9. Хандлага 3-ыг шинжлэхдээ, УСНББОУС3 нь бусад төрлийн хөрөнгүүдийн хэмжилттэй холбоотой УСНББОУС 23-ын шаардлагуудыг харгалзан үзсэн. УСНББОУС 23-ын 13-р параграфт "... тайлагнагч байгууллага нь өөр байгууллагаас түүнд өгсөн үндсэн хөрөнгийн шилжүүлэгтэй холбоотойгоор хүргэлтийн болон угсарч суурилуулах өртөг зардлыг төлөх шаардлагатай бол тэдгээр өртөг зардлыг уг үндсэн хөрөнгийн шилжүүлгээс үүсэх орлогоос тусад нь хүлээн зөвшөөрнө. Хүргэлтийн болон угсарч суурилуулалтын өртгийг УСНББОУС 17-гийн дагуу хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөн дүнд тусган оруулна" гэж заасан байдаг. Энэ нь байгууллага арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн бусад хөрөнгүүдийн хувьд тэдгээрийг анх хэмжихдээ бусад УСНББОУС-ууд, түүнчлэн УСНББОУС 23-ын хэмжилтийн шаардлагуудыг харгалзан үзнэ гэсэн утгыг илэрхийлнэ.

ДҮ10. Биологийн хөрөнгийн хэмжилтэнд хамааралтай нэмэлт шинж нь борлуулах зардал юм. Иймээс байгууллага нь арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн биологийн хөрөнгө ба хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг Хандлага 3-ын дагуу анх хүлээн зөвшөөрөх үедээ борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээр хэмжихийн тулд УСНББОУС 23 болон энэ Стандартын аль алины шаардлагуудыг харгалзан үзнэ гэж УСНББОУС3 дүгнэсэн. Энэ нь Хандлага 2-ын дагуу тайлагнасанатай ижил үр дүнд хүргэнэ гэж УСНББОУС3 онцлон тэмдэглэсэн.

### **Үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилах биологийн хөрөнгө ба хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн**

ДҮ11. НББОУС 41 нь зөвхөн худалдан борлуулах биологийн хөрөнгө ба хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг авч үздэг. Улсын секторын хувьд ийм хөрөнгийг үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилах зорилгоор удирдан зохицуулж болох юм. Саналын Төсөл 36, *Хөдөө Аж Ахуй*-д санал өгсөн зарим хүмүүс нь борлуулах зорилгоор эзэмшиж буй биологийн

хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилт ба үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилах зорилгоор эзэмшиж буй биологийн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилтийг өөр хооронд нь ялган авч үзэх хэрэгтэй гэсэн үзэл бодлыг илэрхийлж байсан. Үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилах зорилгоор эзэмшиж буй бараа материалыг өртөг ба одоогийн орлуулалтын өртгийн аль багаар хэмжинэ гэсэн зарчмыг УСНББОУС 12, *Бараа материал*-д тогтоосон. 34-р параграфт заасан гажих нөхцлийг мөрдөхөөс бусад тохиолдолд өртөг нь энэ Стандарт дахь бэлэн боломжтой сонголт биш юм. Тайлангийн өдрөөр тухайн хөрөнгийг олж эзэмшихийн тулд уг байгууллагын зарцуулах байсан өртөг гэж одоогийн орлуулалтын өртгийг тодорхойлсон бөгөөд энэ нь борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн ойролцоо дүн байдаг. Иймээс Саналын Төсөл 36 дахь арга хандлагыг өөрчлөөгүй.

ДҮ12. Саналын Төсөлд санал өгсөн зарим хүмүүс нь бодит үнэ цэнийн хэмжилтийг ашигласнаар үүсэх олз, гарзыг тухайн биологийн хувьслын процессын явцад санхүүгийн үр дүнгийн тайланд тайлагнах хэрэгтэй эсэхэд бас эргэлзэж байсан. УСНББОУС3-ийн үзэл бодлоор бол бодит үнэ цэнийн хэмжилтээс үүсэх олз, гарзыг санхүүгийн үр дүнгийн тайланд тайлагнах хэрэгтэй. Яагаад гэвэл, ийм тайлагнал нь тухайн биологийн хувьслын процессын явцад хариуцлагын талаархи ач холбогдолтой мэдээллээр хангадаг. Байгууллагууд нь тэдгээр тайлагнасан бодит үнэ цэнийн өөрчлөлтийн үр нөлөөг тайлбарлахын тулд нэмэлт тодруулга хийхээр шийдвэрлэж болох юм.

## Тодруулга

ДҮ13. УСНББОУС3 нь улсын секторын тусгай асуудлуудыг авч үзэх ба дараах зүйлсийг гүйцэтгэхийн тулд тодруулгын шаардлагуудыг нэмж оруулахын тулд цаашдын аливаа тодруулга зохистой эсэхийг харгалзан үзсэн:

- (а) Таваарын болон үржлийн биологийн хөрөнгүүдийг өөр хооронд нь ялган зааглах. Засгийн Газрын Санхүүгийн Статистик (ЗГСС)-ийн Гарын Авлага 2001 (ЗГССГА 2001) нь хэрэглээний хөрөнгийг бараа материал гэж ангилсан, харин энэ Стандарт нь тэдгээрийг биологийн хөрөнгө гэж ангилсан учраас ийм ялган зааглалт зайлшгүй шаардлагатай юм. Ийм ялган зааглалт нь УСНББОУС-ын дагуу бэлтгэсэн тухайн байгууллагын санхүүгийн тайлан ба статистик хэмжилтийн хооронд илүү сайн тохируулга хийх боломж олгодог.
- (б) Борлуулах зорилгоор эзэмшиж буй биологийн хөрөнгө ба үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилах зорилгоор эзэмшиж буй биологийн хөрөнгийг хооронд нь ялгах. Ийм ялган зааглалт нь үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилах зорилгоор эзэмшиж буй биологийн хөрөнгийн хувьд үүссэн, хэрэгжээгүй олз ба гарзыг тодорхойлох боломжийг хэрэглэгчдэд олгоход зайлшгүй шаардлагатай гэж УСНББОУС3 найдаж байна.
- (в) Тайлант үеийн эхэн ба эцсийн хоорондох биологийн хөрөнгийн дансны үнэд орсон өөрчлөлтийн тохируулгын тайланд уг арилжааны

бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн биологийн хөрөнгө болон үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилах зорилгоор эзэмшиж буй биологийн хөрөнгийг тусад нь харуулах. Энэ Стандартын цар хүрээнд хамаарах арилжааны бус ажил гүйлгээний талаар зохих мэдээллээр хангахад ийм тодруулга шаардлагатай байдаг.

- (г) Борлуулах зорилгоор эзэмшиж буй биологийн хөрөнгө ба үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилах зорилгоор эзэмшиж буй биологийн хөрөнгийн хувьд арилжааны бус ажил гүйлгээний үр дүнд үүссэн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тусад нь тодруулах. Үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилах зорилгоор эзэмшиж буй биологийн хөрөнгөнд хамаарах олз, гарзын дүнгийн талаархи мэдээлэл нь засгийн газрын хөтөлбөрийн өртөг зардлыг үнэлж буй тухайн санхүүгийн тайлангийн хэрэглэгч нарт туслалцаа үзүүлэхэд чухал ач холбогдолтой байдаг.
- (д) Биологийн хөрөнгийн нийт болон хязгаарласан дүн гэх мэт тухайн биологийн хөрөнгийг ашиглах буюу худалдан борлуулах уг байгууллагын чадвар боломжинд тавигдах хязгаарлалтын шинж төрөл ба хэмжээг тодорхойлох. УСНББОУСЗ-ийн үзэл бодлоор бол ийм тодруулга нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг бодит үнэ цэнээр борлуулах уг байгууллагын чадвар боломжийн талаар, ингэснээр түүний хэмжилтийн талаар ач холбогдолтой мэдээллээр хангадаг.

### **Шилжилтийн нөхцөл**

ДҮ14. НББОУС 41 нь нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийг анх удаа мөрдөхөд зориулсан шилжилтийн нөхцлийг тусгаагүй байдаг. Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийг анх удаа мөрдөх тохиолдолд энэ Стандартыг даган мөрдөхөд нь байгууллагуудад туслахын тулд ийм шилжилтийн нөхцлийг энэ Стандартыг гаргах үед түүнд тусган оруулсан байсан. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартыг Анх Удаа Мөрдөх*-ын заавар удирдамж нь шилжилтийн нөхцлүүдийг орлох болсноор тэдгээрийг энэ Стандартаас хассан.

### **УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд-ын Хэсэг II: “Санал гаргагчдын дэвшүүлсэн асуудлууд”-ын үр дүнд УСНББОУС 27-д хийсэн хянан засварлалт**

ДҮ15. Санал гаргагчид нь борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба данснаас хасах бүлгийг УСНББОУС тууштай бус илэрхийлсэн гэж үзсэн. СТОУС 5, *Борлуулах Зорилгоор Эзэмшиж Буй Эргэлтийн Бус Хөрөнгө ба Зогсоосон Үйл Ажиллагаа* нь дараах учир шалтгааны улмаас зөвхөн зарим нөхцөл байдалд улсын секторт тохиромжтой байж болох юм гэж УСНББОУСЗ дүгнэсэн:

- (а) Шаардлагатай түвшний зөвшөөрлийн улмаас улсын секторт хөрөнгийн борлуулалтыг нэг жилийн дотор хийж чадахгүй байж болох юм. Энэ нь СТОУС 5-ын дагуу тусгах мэдээллийн

## ХӨДӨӨ АЖ АХУЙ

хамааралтай ба тууштай байдалд эргэлзээ үүсгэдэг. Тухайлбал; борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийг СТОУС 5-ын дагуу элэгдүүлэхгүй гэдгийг УСНББОУСЗ онцлон тэмдэглэсэн. Хөрөнгийг урт хугацаанд элэгдүүлэхгүй байх нь тохиромжгүй гэж УСНББОУСЗ үзэж байна.

- (б) Улсын секторт олон хөрөнгийг үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр шилжүүлэх болон түгээн хуваарилах замаар данснаас хасдаг. СТОУС 5 нь бодит үнэ цэнээр хийх борлуулалтыг авч үздэг тул түүний хэмжилт ба тодруулгын шаардлагууд нь ийм шилжүүлэлтийн хувьд холбогдох мэдээллээр хангадаггүй. Гэвч борлуулалтыг бодит үнэ цэнээр хийх санаа зорилготой байх тохиолдолд СТОУС 5-ын хэмжилт ба тодруулгын шаардлагууд нь тохиромжтой байж болно гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрдөг.
- (в) Улсын сектор дахь зогсоосон олон үйл ажиллагаа нь үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр өмнө үзүүлсэн үйлчилгээ байдаг. СТОУС 5 нь данснаас хасах эсвэл борлуулах зорилгоор эзэмшиж буй гэж дахин ангилахаас өмнө мөнгө бий болгогч нэгжүүд буюу мөнгө бий болгогч нэгжүүдийн бүлэг байсан, тийм зогсоосон үйл ажиллагааг авч үздэг тул түүний тодруулгын шаардлагууд нь улсын секторын зогсоосон үйл ажиллагааны хувьд холбогдох мэдээллээр хангадаггүй байж болох юм. Гэвч зогсоосон үйл ажиллагаа нь өмнө нь мөнгө бий болгогч нэгжүүд буюу мөнгө бий болгогч нэгжүүдийн нэг болон хэд хэдэн бүлгүүд байсан бол СТОУС 5-ын тодруулгын шаардлагууд тохиромжтой байж болно гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрдөг.

СТОУС 5 нь зөвхөн цөөн хязгаарлагдмал нөхцөл байдалд улсын секторт тохиромжтой гэж УСНББОУСЗ дүгнэсэн учраас борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагааг авч үзэх олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн стандартуудын талаархи УСНББОУС дахь хэллэг лавлагааг хасахыг УСНББОУСЗ зөвшөөрсөн. Ийм хэллэг лавлагааг хасалгүй үлдээх нь СТОУС 5-ын шаардлагууд тохиромжгүй байж болох нөхцөл байдалд байгууллагууд түүний шаардлагуудыг даган мөрдөхөд хүргэнэ гэж УСНББОУСЗ санаа зовж байсан. УСНББОУС-уудад тусгайлан авч үзээгүй ажил гүйлгээний хувьд нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох заавар удирдамжаар УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого*, *Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь хангана гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Тохиромжтой гэж тухайн байгууллага үзсэн тохиолдолд СТОУС 5-тай нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тэдгээр байгууллагууд баримтлахыг ийм заавар удирдамжаар зөвшөөрсөн байдаг.

**2014 оны 6 дугаар сард гаргасан, НББОУСЗ-ийн Цар Хүрээний Цөөн Нэмэлт Өөрчлөлтүүд-ийн үр дүнд УСНББОУС 27-д хийсэн хянан засварлалт**

ДҮ16. УСНББОУСЗ нь 2014 оны 6 дугаар сард НББОУСЗ-өөс Хөдөө Аж Ахуй: Эх Ургамал (НББОУС 16 ба НББОУС 41-ийн Нэмэлт өөрчлөлтүүд) нэрээр гаргасан цар хүрээний цөөн нэмэлт өөрчлөлтүүдэд тусгасан, НББОУС 41-ийн хянан засварлалтыг нягталж шалгаад эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдөхгүй байх улсын секторын тусгай учир шалтгаан байхгүй гэдэгтэй ерөнхийдөө санал нийлсэн.

**2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУСЗ-ийн УСНББОУС-ЫН Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 26-д хийсэн хянан засварлалт**

ДҮ17. УСНББОУСЗ нь 2016 оны 4 дүгээр сард УСНББОУС-ЫН Мөрдөгдөх Боломжит Байдал-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (а) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р* параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

## **Үлгэрчилсэн жишээ**

*Энэхүү жишээ нь УСНББОУС 27-г дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

Доор дурдсан ажил гүйлгээний үр нөлөөг харуулахын тулд санхүүгийн үр дүнгийн тайлан болон санхүүгийн байдлын тайлангаас хэсэгчлэн авч илэрхийлэв. Эдгээр хэсэгчлэн авсан ишлэлүүд нь бусад Стандартуудын тодруулга ба толилуулгын бүх шаардлагуудтай нийцсэн байх албагүй юм.

Эхний жишээ нь энэ Стандартын тодруулгын шаардлагуудыг сүүний аж ахуйн байгууллагын практикт хэрхэн хэрэглэхийг үлгэрчлэн харуулсан. Энэ Стандарт нь тухайн байгууллагын биологийн хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн өөрчлөлтийг түүний биет өөрчлөлт болон үнийн өөрчлөлтөөс тусдаа салган харуулахыг дэмждэг. Ийм салган зааглалтыг эхний жишээнд тусган харуулсан. Хоёр дахь жишээ нь биет өөрчлөлт ба үнийн өөрчлөлтийг хэрхэн салган зааглахыг үлгэрлэн харуулсан.

## Тодруулгын шаардлагууд

## Санхүүгийн байдлын тайлан

“XYZ” байгууллага	Тод- руулга	20X8 оны 12-р сарын 31 Тооцооны нэгж (ТН)	20X7 оны 12-р сарын 31 (ТН)
<b>ХӨРӨНГӨ</b>			
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Мөнгө		10,000	10,000
Авлага		88,000	65,000
Бараа материал		82,950	70,650
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>		<b>180,950</b>	<b>145,650</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Үржлийн биологийн хөрөнгө			
Сүүний чиглэлийн мал-Төл <sup>i</sup>		52,060	47,730
Сүүний чиглэлийн мал-Нас бие гүйцсэн <sup>i</sup>		372,990	411,840
Дэд дүн-Үржлийн биологийн хөрөнгө	3	425,050	459,570
Үндсэн хөрөнгө		1,462,650	1,409,800
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>		<b>1,887,700</b>	<b>1,869,370</b>
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>		<b>2,068,650</b>	<b>2,015,020</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>			
<b>Богино хугацаат өр төлбөр</b>			
Өглөг		122,628	150,020
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>122,628</b>	<b>150,020</b>
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧ</b>			
Хувь нийлүүлсэн капитал		1,000,000	1,000,000
Хуримтлагдсан ашиг		946,022	865,000
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>		<b>1,946,022</b>	<b>1,865,000</b>
<b>НИЙТ ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧ</b>		<b>2,068,650</b>	<b>2,015,020</b>

<sup>i, ii</sup> Байгууллага нь таваарын ба үржлийн биологийн хөрөнгийг өөр хооронд нь, борлуулах зорилгоор эзэмшиж буй биологийн хөрөнгө ба үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилах зорилгоор эзэмшиж буй биологийн хөрөнгийг өөр хооронд нь ялган зааглах, биологийн хөрөнгийн тийм тайлбар тодорхойлолтыг бэлтгэх шаардлагатай юм. Ийм тодруулга нь тоон шинжтэй тайлбар тодорхойлолт хэлбэртэй байх бөгөөд түүнийг хүүрнэсэн тайлбар дагалдсан байж болно. Мөн байгууллага нь төл болон нас бие гүйцсэн биологийн хөрөнгийг тохиромжтой байдлаар салган зааглахыг дэмждэг боловч заавал ингэж шаардахгүй. Байгууллага нь ийм аливаа ялган зааглалт хийсэн суурь үндэслэлээ тодруулна. Энэ жишээнд үржлийн биологийн хөрөнгийн тодруулгыг санхүүгийн байдлын тайланд тусган толилуулсан. Тодруулгын бусад шаардлагуудыг хангах мэдээллийг зөвшөөрсний дагуу санхүүгийн тайлангийн тодруулга хэсэгт толилуулдаг.



*Санхүүгийн үр дүнгийн тайлан*

“XYZ” байгууллага	Тод- руулга	20X8 оны 12-р сарын 31 Тооцооны нэгж (ТН)
Үйлдвэрлэсэн сүүний бодит үнэ цэнэ		518,240
Борлуулах зорилгоор эзэмшиж буй сүүний чиглэлийн малын борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз	3	39,930
		<b>558,170</b>
Ашиглан зарцуулсан бараа материал		(137,523)
Ажиллагчдын зардал		(127,283)
Элэгдлийн зардал		(15,250)
Үйл ажиллагааны бусад зардал		(197,092)
		<b>(477,148)</b>
<b>Тайлант үеийн цэвэр ашиг</b>		<b>81,022</b>

*Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан*

	20X8 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жил		
	ТН Хувь нийлүүлсэн капитал	ТН Хуримтлагдсан ашиг	ТН Нийт дүн
Үлдэгдэл, 20X8 оны 01-р сарын 01	1,000,000	865,000	<b>1,865,000</b>
Тайлант үеийн ашиг	-	81,022	<b>81,022</b>
<b>Үлдэгдэл, 20X8 оны 12-р сарын 31</b>	<b>1,000,000</b>	<b>946,022</b>	<b>1,946,022</b>

ХӨДӨӨ АЖ АХУЙ

*Мөнгөн гүйлгээний тайлан*<sup>iii</sup>

“XYZ” байгууллага

20X8 оны 12-р сарын  
31-нээр дуусгавар  
болсон жил

	ТН
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	
Сүүний борлуулалтаас хүлээн авсан мөнгөн орлого	498,027
Малын борлуулалтаас хүлээн авсан мөнгөн орлого	97,913
Хангамжийн зүйлсэд болон ажиллагчдад төлсөн мөнгө	(504,025)
Мал худалдан авахад төлсөн мөнгө	(23,815)
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>68,100</b>
<b>Хөрөнгө оруулалтын ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	(68,100)
<b>Хөрөнгө оруулалтын ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(68,100)</b>
<b>Мөнгөний цэвэр өсөлт</b>	<b>0</b>
<b>Тухайн жилийн эхэн дэх мөнгөний үлдэгдэл</b>	<b>10,000</b>
<b>Тухайн жилийн эцэс дэх мөнгөний үлдэгдэл</b>	<b>10,000</b>

<sup>iii</sup> Энэхүү мөнгөн гүйлгээний тайланд үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг шууд аргаар тайлагнасан. УСНББОУС 2, “Мөнгөн гүйлгээний тайлан” нь шууд арга эсвэл шууд бус аргын аль нэгийг ашигласнаар үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг тайлагнахыг байгууллагуудаас шаарддаг. УСНББОУС 2 нь шууд арга ашиглахыг дэмждэг.

*Тодруулга*

**1. Үйл ажиллагаа ба үндсэн ажиллагаа**

“XYZ” байгууллага (“байгууллага”) нь сүүний үйлдвэрлэл эрхэлдэг. 2008 оны 12 дугаар сарын 31-нд тус байгууллага нь сүү саадаг 419 үнээ (нас бие гүйцсэн үржлийн мал) болон ирээдүйд сүү саахаар өсгөж буй 137 охин бяруутай (үржлийн төл мал) байв. Уг байгууллага нь 2008 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилд борлуулах зардлыг хассан 518,240 төгрөгийн ТН-ийн бодит үнэ цэнэ (энэхүү хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бодит үнэ цэнийг сүүг саах үед тодорхойлсон) бүхий 157,584 кг сүү үйлдвэрлэсэн. Тус байгууллага нь ямар нэг таваарын биологийн хөрөнгийг өмчилдөггүй.

*Мал ба сүү*

**2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого**

Малыг борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээр хэмждэг. Уг малын бодит үнэ цэнийг түүнтэй адилтгах нас, үүлдэр, генийн өгөгдөл бүхий малын зах зээлийн үнэд үндэслэн тодорхойлдог. Сүүг саах үеийн түүний борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээр эхлээд хэмждэг. Сүүний

## ХӨДӨӨ АЖ АХУЙ

бодит үнэ цэнийг тухайн орон нутгийн зах зээлийн үнэд үндэслэн тодорхойлдог.

### 3. Биологийн хөрөнгө

	20X8
<b>Сүүний чиглэлийн малын дансны үнийн тохируулга</b>	<b>ТН</b>
<b>Дансны үнэ, 20X8 оны 01 дүгээр сарын 01</b>	<b>459,570</b>
Худалдан авалтын үр дүнд нэмэгдсэн	26,250
Биет өөрчлөлтөнд хамааруулж болох, борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз <sup>iv</sup>	15,350
Үнийн өөрчлөлтөнд хамааруулж болох, борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз <sup>v</sup>	24,580
Борлуулалтын үр дүнд буурсан	(100,700)
<b>Дансны үнэ, 20X8 оны 12 дугаар сарын 31</b>	<b>425,050</b>

<sup>iv</sup> Борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн нэмэгдэлтийг биет өөрчлөлтөнд хамааруулж болох хэсэг ба үнийн өөрчлөлтөнд хамааруулж болох хэсгээр салган зааглахыг энэ Стандартаар дэмжих боловч заавал шаардахгүй.

<sup>v</sup> Тэмдэглэл <sup>(iii)</sup>-ыг үзнэ үү.

### 4. Санхүүгийн эрсдлийн удирдлагын стратеги

Байгууллага нь сүүний үнийн өөрчлөлтийн улмаас санхүүгийн эрсдэлд өртөнө. Байгууллага нь ойрын ирээдүйд сүүний үнэ мэдэгдэхүйц буурна гэж урьдчилан таамаглахгүй байгаа бөгөөд иймээс сүүний үнийн бууралтын эрсдлийг удирдан зохицуулахын тулд үүсмэл хэрэглүүрийн буюу бусад гэрээг байгуулаагүй. Санхүүгийн эрсдлийн идэвхитэй удирдлагын хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэхдээ, тус байгууллага нь сүүний үнийн талаархи өөрийн таамаглалыг тогтмол хянан шалгадаг.

### Биет өөрчлөлт ба үнийн өөрчлөлт

Биет өөрчлөлт ба үнийн өөрчлөлтийг хэрхэн салган зааглахыг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан. Борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн өөрчлөлтийг биет өөрчлөлтөнд хамааруулж болох хэсэг болон үнийн өөрчлөлтөнд хамааруулж болох хэсгээр салган зааглахыг энэ Стандартаар дэмждэг боловч заавал шаарддаггүй.

20X8 оны 01 дүгээр сарын 01-нд 2 жилийн настай арван ширхэг малтай байсан. 2.5 жилийн настай нэг малыг 20X8 оны 7 дугаар сарын 01-нд 108ТН-ээр худалдан авсан ба 20X8 оны 7 дугаар сарын 01-нд нэг мал шинээр төллөсөн. Тухайн тайлант үеийн туршид өөр ямар нэг мал худалдан борлуулаагүй буюу данснаас хасаагүй. Нэгжийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ нь дараах байдалтай байсан:

ХӨДӨӨ АЖ АХУЙ

	ТН	ТН
2 жилийн настай мал, 20X8 оны 01 дүгээр сарын 01-нд	100	
20X8 оны 7 дугаар сарын 01-нд шинээр төллөсөн мал	70	
2.5 жилийн настай мал, 20X8 оны 7 дугаар сарын 01-нд	108	
20X8 оны 12 дугаар сарын 31-нд шинээр төллөсөн мал	72	
0.5 жилийн настай мал, 20X8 оны 12 дугаар сарын 31-нд	80	
2 жилийн настай мал, 20X8 оны 12 дугаар сарын 31-нд	105	
2.5 жилийн настай мал, 20X8 оны 12 дугаар сарын 31-нд	111	
3 жилийн настай мал, 20X8 оны 12 дугаар сарын 31-нд	120	
Мал сүргийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ, 20X8 оны 01 дүгээр сарын 01-нд (10x100)		1,000
20X8 оны 7 дугаар сарын 01-ний худалдан авалт (1x108)		108
Үнийн өөрчлөлтийн улмаас борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн нэмэгдсэн дүн		
10 x (105-100)	50	
1 x (111-108)	3	
1 x (72-70)	2	55
Биет өөрчлөлтийн улмаас борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн нэмэгдсэн дүн		
10 x (120-105)	150	
1 x (120-111)	9	
1 x (80-72)	8	
1 x 70	70	237
Мал сүргийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ, 20X8 оны 12 дугаар сарын 31-нд		
11 x 120	1,320	
1 x 80	80	1,400

## НББОУС 41-ТЭЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 27, *Хөдөө Аж Ахуй*-г 2008 оны 12 дугаар сарын 31 хүртэл нэмэлт өөрчлөлт оруулсан НББОУС 41, *Хөдөө Аж Ахуй* (2003)-гаас үндсэндээ бэлтгэсэн. УСНББОУС 27 ба НББОУС 41-ийн хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- “Хөдөө аж ахуйн үйл ажиллагаа” тодорхойлолт нь үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр биологийн хөрөнгийг түгээн хуваарилах ажил гүйлгээг тусган агуулсан. НББОУС 41 нь ийм ажил гүйлгээг авч үздэггүй.
- Үйлчилгээ үзүүлэх буюу нийлүүлэх зорилгоор эзэмшиж буй биологийн хөрөнгийг энэ Стандарт авч үзээгүй гэдгийг цар хүрээний хэсэгт тодруулан заасан. НББОУС 41 нь ийм тодруулсан заалтыг тусгаагүй байдаг.
- НББОУС 41 нь борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээр хэмжсэн биологийн хөрөнгөтэй холбоотой засгийн газрын буцалтгүй тусламжийн талаархи шаардлагуудыг тусгасан байдаг. УСНББОУС 23, *Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Татвар ба Шилжүүлэг)* нь арилжааны бус ажил гүйлгээгээр үүссэн засгийн газрын буцалтгүй тусламжтай холбоотой шаардлагууд ба заавар удирдамжаар хангадаг учраас засгийн газрын буцалтгүй тусламжийн талаархи шаардлагууд болон заавар удирдамжийг УСНББОУС 27-д тусган оруулаагүй.
- УСНББОУС 27 нь арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн биологийн хөрөнгийн анх хүлээн зөвшөөрөлтийн болон тайлант үе бүрийн эцэс дэх хэмжилтийн шаардлагуудыг агуулсан байдаг.
- Энэ Стандарт нь биологийн хөрөнгийг ашиглах буюу борлуулах уг байгууллагын чадвар боломжинд хязгаарлалт тогтоосон биологийн хөрөнгийн хувьд нэмэлт тодруулгын шаардлагуудыг тусгасан байдаг.
- Энэ Стандарт нь таваарын ба үржлийн биологийн хөрөнгийг хооронд нь, мөн борлуулах зорилгоор эзэмшиж буй биологийн хөрөнгө ба үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр түгээн хуваарилах зорилгоор эзэмшиж буй биологийн хөрөнгийг хооронд нь ялган тодорхойлох шаардлагуудыг тусгасан байдаг. Ийм тодруулга нь тоон шинжтэй тайлбар тодорхойлолт хэлбэртэй байх бөгөөд түүнийг хүүрнэсэн тайлбар дагалдсан байж болно. Байгууллагууд нь таваарын ба үржлийн биологийн хөрөнгийг хооронд нь, эсвэл төл ба нас бие гүйцсэн биологийн хөрөнгийг өөр хооронд нь тохиромжтой байдлаар ялган зааглаж, биологийн хөрөнгийн бүлэг тус бүрийн талаар тоон шинжтэй тайлбар тодорхойлолт бэлтгэхийг НББОУС 41-ээр дэмждэг боловч заавал шаардахгүй.
- Энэ Стандарт нь аккруэл нягтлан бодох бүртгэлийг анх удаа мөрдөх талаархи шилжилтийн нөхцлүүдийг агуулсан байдаг. НББОУС 41 нь ийм шилжилтийн нөхцлийг заагаагүй.
- УСНББОУС 27 нь зарим тохиолдолд НББОУС 41-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь УСНББОУС 27 дахь

## ХӨДӨӨ АЖ АХУЙ

“ирээдүйн эдийн засгийн үр өгөөж ба үйлчилгээний чадавхи”, “ашиг, алдагдал /surplus or deficit/”, “санхүүгийн үр дүнгийн тайлан” гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. НББОУС 41 дэх адилтгах нэр томъёо нь “ирээдүйн эдийн засгийн үр өгөөж”, “ашиг, алдагдал /profit or loss/”, “дэлгэрэнгүй орлогын тайлан” юм.

## УСНББОУС 28–САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОЛИЛУУЛГА

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) 32, *Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга* ба Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Тайлбарын Хорооны Тайлбар 2 (СТОУТХ 2), *Хоршоон дахь Гишүүдийн Хувь Оролцоо ба Адилтгах Хэрэглүүрүүд*-ээс үндсэндээ бэлтгэсэн болно. НББОУС 32 ба СТОУТХ 2-оос авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон EC4M 6XH, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)

Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.

## УСНББОУС 28-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОЛИЛУУЛГА

### УСНББОУС-ын түүх

Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

УСНББОУС 28, Санхүүгийн Хэрэглүүр: Топилуулга-ыг 2010 оны 01 дүгээр сард гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 28-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС 39, Ажилтны Тэтгэмж (2016 оны 7 дугаар сард гаргасан)
- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 37, Хамтын Хэлэлцээр (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 35, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2014-ийн Сайжруулалтууд (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2011-ийн Сайжруулалтууд (2011 оны 10 дугаар сард гаргасан)

### УСНББОУС 26-гийн нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт

Өөрчлөгдсөн параграф	Хэрхэн өөрчилсөн	Юугаар өөрчилсөн
Танилцуулга хэсэг	Хассан	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
3	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар УСНББОУС 37, 2015 оны 01-р сар УСНББОУС 39, 2016 оны 7-р сар
7	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
8	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
40	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2015 оны 01-р сар
40А	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2015 оны 01-р сар
42	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2015 оны 01-р сар



САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОЛИЛУУЛГА

44	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2015 оны 01-р сар
56	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
57	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
58	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
60А	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2015 оны 01-р сар
60Б	Шинэ	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
60В	Шинэ	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
60Г	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
60Д	Шинэ	УСНББОУС 39, 2016 оны 7-р сар
61	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
МЗУ53	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар

**УСНББОУС 28–САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОЛИЛУУЛГА**

**АГУУЛГА**

	Параграф
Зорилго	1-2
Цар хүрээ	3-8
Тодорхойлолт	9-12
Толилуулга	13-55
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмч	13-32
Буцаах эрхтэй хэрэглүүр	15-16
Байгууллагыг зөвхөн татан буулгах үед түүний цэвэр хөрөнгөөс хувь тэнцүүлэн нөгөө талдаа өгөх үүргийг тухайн байгууллагад хүлээлгэдэг хэрэглүүр буюу хэрэглүүрийн бүрэлдэхүүн хэсгүүд	17-18
Байгууллагыг зөвхөн татан буулгах үед түүний цэвэр хөрөнгөөс хувь тэнцүүлэн нөгөө талдаа өгөх үүргийг тухайн байгууллагад хүлээлгэдэг хэрэглүүр ба буцаах эрхтэй хэрэглүүрийн дахин ангилал	19-20
Мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг өгөх гэрээний үүрэггүй байх	21-24
Байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрээр барагдуулалт	25-29
Төлбөр барагдуулалтын болзошгүй нөхцлүүд	30
Барагдуулалтын сонголтууд	31-32
Нийлмэл санхүүгийн хэрэглүүр	33-37
Халаасны хувьцаа	38-39
Хүү, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт, олз ба гарз	40-46
Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийг харилцан суутгаж, цэвэр дүн гаргалт	47-55
Шилжилтийн нөхцөл	56-58
Хүчин төгөлдөр болох хугацаа	59-61
УСНББОУС 15 (2001)-аас татгалзах	62
Хавсралт А: Мөрдөх заавар удирдамж	
Хавсралт Б: Хоршоон дахь Гишүүдийн Хувь Оролцоо ба Адилтгах Хэрэглүүрүүд	
Хавсралт В: Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт	
Дүгнэлтийн үндэслэл	
Үлгэрчилсэн жишээ	
НББОУС 32-той харьцуулалт	

## САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОЛИЛУУЛГА

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 28, *Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга*-ыг 1-62-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 28-ыг түүний зорилгын агуулга, Дүгнэлтийн Үндэслэл, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

1. Энэ Стандартын зорилго нь санхүүгийн хэрэглүүрийг өр төлбөр эсвэл цэвэр хөрөнгө/өмч байдлаар толилуулах, түүнчлэн санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийг харилцан суутгаж, цэвэр дүн гаргах зарчмуудыг тогтооход оршино. Гаргагчийн зүгээс санхүүгийн хэрэглүүрийг санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөр, өмчийн хэрэглүүр гэж ангилах ангилал; холбогдох хүү, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт, олз ба гарзын ангилал; санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийг харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах нөхцөл байдал зэргийн хувьд Стандартыг мөрдөнө.
2. Энэ Стандартад заасан зарчмууд нь санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрч, хэмжих УСНББОУС 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*-ийн зарчмууд болон санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийн талаархи мэдээллийг тодруулах УСНББОУС 30, *Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга*-ын зарчмуудын нэмэлт гүйцээлт юм.

## Цар хүрээ (Мөн МЗУЗ-МЗУ9-р параграфуудыг үзнэ үү)

3. Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь доор дурдсанаас бусад бүх төрлийн санхүүгийн хэрэглүүрийн хувьд энэ Стандартыг мөрдөнө:
  - (a) УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 34, *Тусдаа Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*-ын дагуу тайлагнадаг хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоо. Гэвч зарим тохиолдолд УСНББОУС 34, УСНББОУС 35, УСНББОУС 36 нь хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоог УСНББОУС 29-ийг ашиглан тайлагнахыг байгууллагаас шаарддаг буюу зөвшөөрдөг; ийм тохиолдолд байгууллагууд нь энэ Стандартын шаардлагуудыг мөрдөнө. Мөн байгууллагууд нь хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоотой холбоотой бүх үүсмэл хэрэглүүрийн хувьд энэ Стандартыг мөрдөнө.
  - (б) УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийг мөрдөх ажилтны тэтгэмжийн хөтөлбөрийн дагуу хүлээх ажил олгогчийн эрх ба үүрэг;
  - (в) Даатгалын гэрээнээс үүссэн үүрэг. Гэвч доорх зүйлсийн хувьд энэ Стандартыг мөрдөнө:

- (i) Даатгалын гэрээнүүдийг дагалдах, үүсмэл хэрэглүүрийг хэрэв УСНББОУС 29 нь тусдаа тайлагнахыг уг байгууллагаас шаарддаг бол дагалдах үүсмэл хэрэглүүрт;
- (ii) Гаргагч нь тухайн гэрээг хүлээн зөвшөөрөх ба хэмжихдээ УСНББОУС 29-ийг мөрддөг боловч уг гаргагч нь тэдгээрийг хүлээн зөвшөөрөх ба хэмжихдээ даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг мөрдөх сонголт хийсэн тохиолдолд тэрхүү стандартыг мөрддөг санхүүгийн баталгааны гэрээ.

Дээрх (i) ба (ii)-д дурдснаас гадна, байгууллага нь санхүүгийн эрсдлийн шилжүүлгийг агуулсан даатгалын гэрээний хувьд энэхүү Стандартыг мөрдөж болох юм.

- (г) Сонголттой оролцох шинжийг агуулсан учраас даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартын цар хүрээнд хамаарах санхүүгийн хэрэглүүрүүд. Ийм санхүүгийн хэрэглүүрийн гаргагч нь санхүүгийн өр төлбөр ба өмчийн хэрэглүүрийн хоорондох ялгаатай байдлын талаархи энэ Стандартын 13-37-р болон МЗУ49-МЗУ60-р параграфуудыг эдгээр шинжүүдэд мөрдөхөөс чөлөөлөгдөнө. Харин эдгээр хэрэглүүр нь энэ Стандартын бусад бүх шаардлагуудад захирагдана. Түүнчлэн, эдгээр хэрэглүүрийг дагалдах, үүсмэл хэрэглүүрүүдэд энэ Стандартыг мөрдөнө (УСНББОУС 29-ийг үзнэ үү).
- (д) Хувьцаанд суурилсан төлбөрийг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг мөрдөх доор дурдснаас бусад, хувьцаанд суурилсан төлбөртэй ажил гүйлгээний дагуух санхүүгийн хэрэглүүр, гэрээ ба үүрэг:
  - (i) Энэ Стандартын 4-6-р параграфын цар хүрээнд хамаарах бөгөөд энэ Стандартыг мөрдөх гэрээнүүд;
  - (ii) Ажилтны хувьцааны опционы хөтөлбөр, ажилтны хувьцаа худалдан авах хөтөлбөр болон хувьцаанд суурилсан төлбөр бүхий бусад бүх хэлцэлтэй холбоотойгоор худалдан авсан, борлуулсан, гаргасан буюу хүчингүй болгосон бөгөөд энэ Стандартын 38 ба 39-р параграфыг мөрдөх халаасны хувьцаа.

4. Санхүүгийн бус зүйлийг худалдан авах буюу борлуулах бөгөөд цэвэр дүнгээр нь мөнгөөр буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулах, эсвэл санхүүгийн хэрэглүүрүүдээр солилцож болох гэрээнүүдэд, тэдгээр гэрээ нь өөрөө санхүүгийн хэрэглүүр байсан мэтээр энэхүү Стандартыг мөрдөнө; харин байгууллагын хүлээгдэж буй худалдан авалт, борлуулалт буюу ашиглалтын шаардлагуудын дагуу санхүүгийн бус зүйлийг хүлээн авах эсвэл өгөх зорилгоор байгуулсан ба ийм зорилгоор үргэлжлүүлэн эзэмшиж буй гэрээнүүдэд хамаарахгүй.

5. Санхүүгийн бус зүйлийг худалдан авах буюу борлуулах гэрээг цэвэр дүнгээр нь мөнгөөр буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулах эсвэл санхүүгийн хэрэглүүрүүдийг солилцох янз бүрийн арга замууд байдаг. Үүнд:
- (а) Цэвэр дүнгээр нь мөнгөөр буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулах, эсвэл санхүүгийн хэрэглүүрүүдийг солилцохыг аль нэг талд зөвшөөрсөн гэрээний нөхцөлтэй тохиолдол;
  - (б) Цэвэр дүнгээр нь мөнгөөр буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулах, эсвэл санхүүгийн хэрэглүүрүүдийг солилцох боломжит байдлыг тухайн гэрээний нөхцөлд тодорхой заагаагүй боловч уг байгууллага нь ижил төсөөтэй гэрээг цэвэр дүнгээр нь мөнгөөр буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулсан эсвэл санхүүгийн хэрэглүүрүүдийг солилцсон практик туршлагатай тохиолдол (харилцан суутгаж, цэвэр дүн гаргах гэрээг нөгөө талтайгаа байгуулснаар, эсвэл гэрээ хэрэгжих буюу түүний хугацаа дуусахаас өмнө уг гэрээг борлуулснаар);
  - (в) Ижил төсөөтэй гэрээний хувьд байгууллага нь тухайн хэрэглүүрийг гаргах ба түүний үнийн богино хугацааны хэлбэлзлээс эсвэл дилерийн үнийн зөрүүгээс ашиг олох зорилгоор уг гаргалтаас хойшхи богино хугацааны дотор буцаан борлуулж байсан практик туршлагатай тохиолдол; мөн
  - (г) Тухайн гэрээнд хамаарах санхүүгийн бус зүйлийг мөнгөнд шууд хөрвүүлэх боломжтой тохиолдол.

Тухайн байгууллагын хүлээгдэж буй худалдан авалт, борлуулалт буюу ашиглалтын шаардлагуудын дагуу санхүүгийн бус зүйлийг хүлээн авах эсвэл өгөх тийм зорилгоор дээрх (б) буюу (в) заалтанд хамаарах гэрээг байгуулаагүй бол уг гэрээ нь энэ Стандартын цар хүрээнд хамаарна. Тухайн байгууллагын хүлээгдэж буй худалдан авалт, борлуулалт буюу ашиглалтын шаардлагын дагуу санхүүгийн бус зүйлийг хүлээн авах эсвэл өгөх зорилгоор гэрээг байгуулсан ба ийм зорилгоор үргэлжлүүлэн эзэмшиж буй эсэх, уг гэрээ нь энэ Стандартын цар хүрээнд хамаарах эсэхийг тодорхойлохын тулд 4-р параграфт хамаарах бусад гэрээнүүдийг үнэлж үзнэ.

6. 5(а) буюу (г) параграфын дагуу, цэвэр дүнгээр нь мөнгөөр буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулах эсвэл санхүүгийн хэрэглүүрээр солилцох боломжтой санхүүгийн бус зүйлийг худалдан авах буюу борлуулахаар гаргасан опцион нь энэ Стандартын цар хүрээнд хамаарна. Ийм гэрээг тухайн байгууллагын хүлээгдэж буй худалдан авалт, борлуулалт буюу ашиглалтын шаардлагуудын дагуу санхүүгийн бус зүйлийг хүлээн авах эсвэл өгөх зорилгоор байгуулахгүй.
7. [Хассан]
8. [Хассан]

## Тодорхойлолт (Мөн МЗУ10-МЗУ48-р параграфуудыг үзнэ үү)

9. Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:

**Өмчийн хэрэглүүр** гэдэг нь бүх өр төлбөрийг хассаны дараа байгууллагын хөрөнгөнд үлдэх хувь оролцоог илэрхийлэх аливаа гэрээ юм.

**Санхүүгийн хэрэглүүр** гэдэг нь нэг байгууллагын хувьд санхүүгийн хөрөнгө, нөгөө байгууллагын хувьд санхүүгийн өр төлбөр эсвэл өмчийн хэрэглүүр үүсэхэд хүргэдэг аливаа гэрээ юм.

**Санхүүгийн хөрөнгө** нь дараах аливаа хөрөнгө юм:

- (a) Мөнгө;
- (б) Өөр байгууллагын өмчийн хэрэглүүр;
- (в) Доорх гэрээний эрх:
  - (i) Өөр байгууллагаас мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг хүлээн авах; эсвэл
  - (ii) Санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийг тухайн байгууллагад тааламжтай байх нөхцлөөр өөр байгууллагатай солилцох; эсвэл
- (г) Тухайн байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрээр барагдуулах буюу барагдуулж болох гэрээ ба үүнд:
  - (i) Уг байгууллага нь өөрийн өмчийн хэрэглүүрийг тогтмол бус тоо ширхэгээр хүлээн авах үүрэг хүлээсэн буюу хүлээж болох үүсмэл бус хэрэглүүр; эсвэл
  - (ii) Тухайн байгууллагын тогтмол тоо ширхэгтэй өөрийн өмчийн хэрэглүүрийн хариуд тогтмол дүн бүхий мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг солилцохоос бусад байдлаар барагдуулах буюу барагдуулж болох үүсмэл хэрэглүүр. Энэ зорилгын хувьд тухайн байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрт дараах зүйлс хамаарахгүй: 15 ба 16-р параграфын дагуу өмчийн хэрэглүүр гэж ангилсан буцаах эрхтэй санхүүгийн хэрэглүүр; тухайн байгууллагыг зөвхөн татан буулгах үед түүний цэвэр хөрөнгөөс хувь тэнцүүлэн нөгөө талдаа өгөх үүргийг уг байгууллагад хүлээлгэдэг бөгөөд 17, 18-р параграфын дагуу өмчийн хэрэглүүр гэж ангилсан хэрэглүүр; тухайн байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрийг ирээдүйд хүлээн авах эсвэл өгөх тийм гэрээ болох хэрэглүүр.

**Санхүүгийн өр төлбөр нь дараах аливаа өр төлбөр юм:**

- (a) **Доорх гэрээний үүрэг:**
- (i) **Өөр байгууллагад мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг өгөх; эсвэл**
  - (ii) **Санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийг тухайн байгууллагад тааламжгүй байх нөхцлөөр өөр байгууллагатай солилцох; эсвэл**
- (б) **Тухайн байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрээр барагдуулах буюу барагдуулж болох гэрээ ба үүнд:**
- (i) **Уг байгууллага нь өөрийн өмчийн хэрэглүүрийг тогтмол бус тоо ширхэгээр өгөх үүрэг хүлээсэн буюу хүлээж болох үүсмэл бус хэрэглүүр; эсвэл**
  - (ii) **Тухайн байгууллагын тогтмол тоо ширхэгтэй өөрийн өмчийн хэрэглүүрийн хариуд тогтмол дүн бүхий мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг солилцохоос бусад байдлаар барагдуулах буюу барагдуулж болох үүсмэл хэрэглүүр. Энэ зорилгын хувьд тухайн байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрт дараах зүйлс хамаарахгүй: 15 ба 16-р параграфын дагуу өмчийн хэрэглүүр гэж ангилсан буцаах эрхтэй санхүүгийн хэрэглүүр; тухайн байгууллагыг зөвхөн татан буулгах үед түүний цэвэр хөрөнгөөс хувь тэнцүүлэн нөгөө талдаа өгөх үүргийг уг байгууллагад хүлээлгэдэг бөгөөд 17, 18-р параграфын дагуу өмчийн хэрэглүүр гэж ангилсан хэрэглүүр; тухайн байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрийг ирээдүйд хүлээн авах эсвэл өгөх тийм гэрээ болох хэрэглүүр.**

Хэрэв санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангах хэрэглүүр нь 15, 16-р параграфт эсвэл 17, 18-р параграфт заасан бүх шинжүүдтэй ба нөхцлүүдийг хангаж байвал гажих тохиолдол болгон уг хэрэглүүрийг өмчийн хэрэглүүр гэж ангилна.

**Буцаах эрхтэй хэрэглүүр** гэдэг нь гаргагч талд уг хэрэглүүрийг буцаан өгч, мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнө авах эрхийг эзэмшигчдээ олгодог эсвэл ирээдүйд тодорхой бус үйл явдал гарч тохиолдох буюу хэрэглүүрийг эзэмшигч нас барах, тэтгэвэрт гарах үед тухайн гаргагч талд автоматаар буцаадаг санхүүгийн хэрэглүүр юм.

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь*-д дахин нийтэлсэн болно.



10. Дараах нэр томъёог УСНББОУС 29-ийн 10-р параграфт тодорхойлсон бөгөөд түүнд заасан утгаар энэхүү Стандартад хэрэглэнэ:
- Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртөг;
  - Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө;
  - Үл хүлээн зөвшөөрөлт;
  - Үүсмэл хэрэглүүр;
  - Үр ашигт хүүний арга;
  - Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр;
  - Санхүүгийн баталгааны гэрээ;
  - Арилжааны баталгаа;
  - Урьдчилан таамагласан ажил гүйлгээ;
  - Хейжийн үр дүнтэй байдал;
  - Хейжийн зүйл;
  - Хейжийн хэрэглүүр;
  - Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт;
  - Зээл ба авлага;
  - Ердийн нөхцлөөр худалдан авалт буюу борлуулалт;
  - Ажил гүйлгээний зардал.
11. Энэ Стандартад дурдсан “гэрээ” болон “гэрээний” гэсэн нэр томъёо нь хоёр буюу хэд хэдэн талуудын хоорондох, эдийн засгийн тодорхой үр дагавартай ба хуулийн дагуу ихэвчлэн хүчин төгөлдөр хэрэгжих тул талууд өөрийн дураар зайлсхийх боломжгүй буюу боломж багатай тийм хэлцлийг илэрхийлнэ. Гэрээ, түүнчлэн санхүүгийн хэрэглүүр нь янз бүрийн хэлбэртэй байж болох бөгөөд заавал бичгэн байх албагүй юм.
12. Энэ Стандартад дурдсан “байгууллага” гэсэн нэр томъёонд улсын секторын байгууллагууд, хувь хүн, нөхөрлөл, хувьцаат компани, итгэмжлэлийн сан хамаарна.

## **Толилуулга**

**Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмч (Мөн МЗУ49-МЗУ54-р параграфуудыг үзнэ үү)**

13. **Санхүүгийн хэрэглүүрийг гаргагч нь уг хэрэглүүр буюу түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн гэрээ**

**хэлцлийн мөн чанар болон санхүүгийн өр төлбөр, санхүүгийн хөрөнгө, өмчийн хэрэглүүрийн тодорхойлолтын дагуу санхүүгийн өр төлбөр, санхүүгийн хөрөнгө эсвэл өмч хэрэглүүр гэж ангилна.**

14. Санхүүгийн хэрэглүүр нь санхүүгийн өр төлбөр биш, харин өмчийн хэрэглүүр болох эсэхийг тодорхойлохын тулд гаргагч нь 9-р параграфт заасан тодорхойлолтыг ашиглах бол дараах (а) ба (б) заалтанд дурдсан нөхцлүүд хоёулаа хангагдаж байх зөвхөн тийм тохиолдолд уг хэрэглүүрийг өмчийн хэрэглүүр гэж үзнэ.

(а) Уг хэрэглүүр нь доорх гэрээний үүргийг агуулаагүй байх:

- (i) Өөр байгууллагад мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг өгөх; эсвэл
- (ii) Санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийг тухайн гаргагчийн хувьд тааламжгүй байх нөхцлөөр өөр байгууллагатай солилцох.

(б) Хэрэв уг хэрэглүүрийг тухайн гаргагчийн өөрийн өмчийн хэрэглүүрээр барагдуулах буюу барагдуулж болох бол энэ нь:

- (i) Гаргагч өөрийн өмчийн хэрэглүүрийг тогтмол бус тоо ширхэгээр өгөх тийм гэрээний үүргийг агуулаагүй үүсмэл бус хэрэглүүр байх; эсвэл
- (ii) Гаргагч тогтмол тоо ширхэгтэй өөрийн өмчийн хэрэглүүрийн хариуд тогтмол дүн бүхий мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг солилцоноор зөвхөн барагдуулж болох үүсмэл хэрэглүүр байх. Энэ зорилгын хувьд гаргагчийн өөрийн өмчийн хэрэглүүрт дараах хэрэглүүр хамаарахгүй: 15, 16-р параграфт эсвэл 17, 18-р параграфт заасан бүх шинжүүдтэй ба нөхцлүүдийг хангах хэрэглүүр; тухайн гаргагчийн өөрийн өмчийн хэрэглүүрийг ирээдүйд хүлээн авах эсвэл өгөх тийм гэрээ болох хэрэглүүр.

Гэрээний үүрэг, үүн дотроо үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс үүссэн үүрэг нь тухайн гаргагчийн өөрийн өмчийн хэрэглүүрийг ирээдүйд хүлээн авах эсвэл өгөхөд хүргэдэг буюу хүргэж болох боловч дээрх (а) ба (б)-д заасан нөхцлийг хангахгүй, иймээс өмчийн хэрэглүүр биш юм. Хэрэв санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангах хэрэглүүр нь 15, 16-р параграфт эсвэл 17, 18-р параграфт заасан бүх шинжүүдтэй ба нөхцлүүдийг хангаж байвал гажих тохиолдол болгон уг хэрэглүүрийг өмчийн хэрэглүүр гэж ангилна.

#### *Буцаах эрхтэй хэрэглүүр*

15. Буцаах эрхтэй санхүүгийн хэрэглүүр нь уг буцаах эрх хэрэгжсэн үед тэрхүү хэрэглүүрийг мөнгөөр эсвэл бусад санхүүгийн хөрөнгөөр буцаан худалдан авах буюу эргэлтээс гаргах тухайн гаргагчийн гэрээний үүргийг агуулсан байдаг. Ийм үүргийг агуулсан хэрэглүүр нь дараах бүх

шинжүүдтэй бол санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтын гажих нөхцөл болгон уг хэрэглүүрийг өмчийн хэрэглүүр гэж ангилна:

- (a) Хэрэглүүр нь тухайн байгууллага татан буугдах үед уг байгууллагын цэвэр хөрөнгөөс хувь тэнцүүлэн авах эрхийг эзэмшигчдээ олгодог. Тухайн байгууллагын цэвэр хөрөнгө нь түүний хөрөнгөнд гаргах бусад бүх нэхэмжлэлүүдийг хассаны дараа үлдэх хөрөнгө юм. Хувь тэнцүүлсэн хэсгийг дараах байдлаар тодорхойлно:
  - (i) Татан буулгах үед тухайн байгууллагын цэвэр хөрөнгийг тэнцүү дүн бүхий нэгжүүдэд хуваах; ба
  - (ii) Уг санхүүгийн хэрэглүүрийн эзэмшигчид ногдох нэгжийн тоогоор энэхүү тэнцүү дүнг үржүүлэх.
- (б) Уг хэрэглүүр нь хэрэглүүрүүдийн бусад бүх ангиудтай харьцуулахад тэргүүн бус ээлжийн<sup>1</sup> эрхтэй хэрэглүүрийн ангид хамаардаг байх. Ийм ангид хамаарахын тулд уг хэрэглүүр нь:
  - (i) Тухайн байгууллагыг татан буулгах үед түүний хөрөнгөнд гаргах бусад нэхэмжлэлүүдтэй харьцуулахад тэргүүн ээлжийн эрхгүй байх; ба
  - (ii) Хэрэглүүрийн бусад бүх ангиудтай харьцуулахад тэргүүн бус ээлжийн эрхтэй тийм хэрэглүүрийн ангид хамаарахаас өмнө түүнийг өөр хэрэглүүрт хөрвүүлэх шаардлагагүй байх.
- (в) Хэрэглүүрүүдийн бусад бүх ангиудтай харьцуулахад тэргүүн бус ээлжийн эрхтэй ангид хамаарах бүх санхүүгийн хэрэглүүр нь ижил төсөөтэй шинжүүдтэй байна. Тухайлбал; эдгээр нь бүгд буцаах эрхтэй байх ёстой бөгөөд буцаан худалдан авах буюу эргэлтээс гаргах үнийг тооцоолоход ашигласан томъёо буюу бусад арга нь тухайн ангийн бүх хэрэглүүрийн хувьд ижил байна.
- (г) Хэрэглүүрийг мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгөөр буцаан худалдан авах эсвэл эргэлтээс гаргах тухайн гаргагчийн гэрээний үүргийг эс тооцвол уг хэрэглүүр нь мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг өөр байгууллагад өгөх эсвэл тухайн байгууллагад тааламжгүй байх нөхцлөөр санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг өөр байгууллагатай солилцох аливаа гэрээний үүргийг агуулаагүй бөгөөд санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтын (б) дэд параграфт заасанчлан, тухайн байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрээр барагдах буюу барагдаж болох тийм гэрээ биш байх.
- (д) Хэрэглүүрийн хүчин төгөлдөр хугацааны туршид уг хэрэглүүрт хамаарах хүлээгдэж буй нийт мөнгөн гүйлгээ нь тухайн

---

<sup>1</sup> Priority-Тэргүүн ээлжийн эрх-Энэ нь байгууллагыг татан буулгах гэх мэт тохиолдолд өр төлбөрийг барагдуулахад бусад өр төлбөрөөс эхэлж төлөгдөх эрхийг илэрхийлдэг хуулийн нэр томъёо юм. Монгол улсын Иргэний хуулинд тэргүүн ээлжийн эрхтэй байх тохиолдлуудыг дурдсан байдаг. Харин Subordinate-Тэргүүн бус ээлжийн эрх гэдэг нь үүний эсрэг буюу тэргүүн бус ээлжийн эрхийг илэрхийлэх хуулийн нэр томъёо юм. Ред.Ч.Д.

байгууллагын ашиг алдагдал, хүлээн зөвшөөрсөн цэвэр хөрөнгийн өөрчлөлт эсвэл хүлээн зөвшөөрсөн ба хүлээн зөвшөөрөөгүй цэвэр хөрөнгийн бодит үнэ цэнэд уг хэрэглүүрийн хүчин төгөлдөр хугацааны туршид гарсан өөрчлөлтөнд (тухайн хэрэглүүрийн аливаа үр нөлөө үүнд хамаарахгүй) ихэвчлэн үндэслэдэг байх.

16. Өмчийн хэрэглүүр гэж ангилагдахын тулд уг хэрэглүүр нь дээр дурдсан бүх шинжүүдтэй байхаас гадна түүний гаргагч нь доорх шинж бүхий өөр бусад санхүүгийн хэрэглүүр буюу гэрээтэй байх ёсгүй:

- (а) Тухайн байгууллагын ашиг буюу алдагдал, хүлээн зөвшөөрсөн цэвэр хөрөнгийн өөрчлөлт эсвэл хүлээн зөвшөөрсөн ба хүлээн зөвшөөрөөгүй цэвэр хөрөнгийн бодит үнэ цэнэд гарсан өөрчлөлтөнд (ийм хэрэглүүр буюу гэрээний аливаа үр нөлөө үүнд хамаарахгүй) ихэвчлэн үндэслэдэг нийт мөнгөн гүйлгээтэй; ба
- (б) Буцаах эрхтэй хэрэглүүрийн эзэмшигчдэд олгох уг үлдэх өгөөжийг мэдэгдэхүйц хязгаарлах буюу засварлан тогтоох үр нөлөөтэй.

Хэрэглүүрийг эзэмшдэггүй тал ба тухайн гаргагч байгууллагын хооронд хийгдэж болох гэрээний нөхцлүүд болон гэрээтэй адилтгах хэлцлийн болзлуудтай ижил төсөөтэй гэрээний нөхцөл, болзол бүхий, 15-р параграфт заасан хэрэглүүрийн эзэмшигчтэй хийсэн санхүүгийн бус гэрээг тухайн байгууллага нь дээрх нөхцлийг мөрдөх зорилгоор харгалзан үзэхгүй. Хэрэв байгууллага нь дээрх нөхцөл хангагдсан эсэхийг тодорхойлж чадахгүй бол уг буцаах эрхтэй хэрэглүүрийг өмчийн хэрэглүүр гэж ангилахгүй.

*Байгууллагыг зөвхөн татан буулгах үед түүний цэвэр хөрөнгөөс хувь тэнцүүлэн нөгөө талдаа өгөх үүргийг тухайн байгууллагад хүлээлгэдэг хэрэглүүр буюу хэрэглүүрийн бүрэлдэхүүн хэсгүүд*

17. Зарим санхүүгийн хэрэглүүр нь тухайн байгууллагыг зөвхөн татан буулгах үед түүний цэвэр хөрөнгөөс хувь тэнцүүлэн нөгөө талдаа өгөх үүргийг уг гаргагч байгууллагад хүлээлгэх тийм гэрээний үүргийг агуулсан байдаг. Татан буулгах нь тодорхой болсон ба тухайн байгууллагын хяналтаас гадуур байх (жишээлбэл, хязгаарлагдмал хугацаатай байгууллага) эсвэл татан буулгах эсэх нь тодорхой бус боловч уг хэрэглүүрийн эзэмшигчийн сонголтоос хамаарах тул үүрэг үүсдэг. Ийм үүргийг агуулсан хэрэглүүр нь дараах бүх шинжүүдтэй бол санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтын гажих нөхцөл болгон уг хэрэглүүрийг өмчийн хэрэглүүр гэж ангилна:

- (а) Хэрэглүүр нь тухайн байгууллага татан буугдах үед уг байгууллагын цэвэр хөрөнгөөс хувь тэнцүүлэн авах эрхийг эзэмшигчдээ олгодог. Тухайн байгууллагын цэвэр хөрөнгө нь түүний хөрөнгөнд гаргах бусад бүх нэхэмжлэлүүдийг хассаны дараа үлдэх хөрөнгө юм. Хувь тэнцүүлсэн хэсгийг дараах байдлаар тодорхойлно:
  - (i) Татан буулгах үед тухайн байгууллагын цэвэр хөрөнгийг тэнцүү дүн бүхий нэгжүүдэд хуваах; ба

- (ii) Уг санхүүгийн хэрэглүүрийн эзэмшигчид ногдох нэгжийн тоогоор энэхүү тэнцүү дүнг үржүүлэх.
  - (б) Уг хэрэглүүр нь хэрэглүүрүүдийн бусад бүх ангиудтай харьцуулахад тэргүүн бус ээлжийн эрхтэй хэрэглүүрийн ангид хамаардаг байх. Ийм ангид хамаарахын тулд уг хэрэглүүр нь:
    - (i) Тухайн байгууллагыг татан буулгах үед түүний хөрөнгөнд гаргах бусад нэхэмжлэлүүдтэй харьцуулахад тэргүүн ээлжийн эрхгүй байх; ба
    - (ii) Хэрэглүүрийн бусад бүх ангиудтай харьцуулахад тэргүүн бус ээлжийн эрхтэй тийм хэрэглүүрийн ангид хамаарахаас өмнө түүнийг өөр хэрэглүүрт хөрвүүлэх шаардлагагүй байх.
  - (в) Хэрэглүүрүүдийн бусад бүх ангиудтай харьцуулахад тэргүүн бус ээлжийн эрхтэй ангид хамаарах бүх санхүүгийн хэрэглүүр нь тухайн гаргагч байгууллага татан буугдах үед түүний цэвэр хөрөнгөөс хувь тэнцүүлэн өгөх үүргийг уг гаргагч байгууллагад хүлээлгэх тийм ижил төсөөтэй гэрээний үүргийг агуулсан байх ёстой.
18. Өмчийн хэрэглүүр гэж ангилагдахын тулд уг хэрэглүүр нь дээр дурдсан бүх шинжүүдтэй байхаас гадна түүний гаргагч нь доорх шинж бүхий өөр бусад санхүүгийн хэрэглүүр буюу гэрээтэй байх ёсгүй:
- (а) Тухайн байгууллагын ашиг буюу алдагдал, хүлээн зөвшөөрсөн цэвэр хөрөнгийн өөрчлөлт эсвэл хүлээн зөвшөөрсөн ба хүлээн зөвшөөрөөгүй цэвэр хөрөнгийн бодит үнэ цэнэд гарсан өөрчлөлтөнд (ийм хэрэглүүр буюу гэрээний аливаа үр нөлөө үүнд хамаарахгүй) ихэвчлэн үндэслэдэг нийт мөнгөн гүйлгээтэй; ба
  - (б) Тухайн хэрэглүүрийн эзэмшигчдэд олгох уг үлдэх өгөөжийг мэдэгдэхүйц хязгаарлах буюу засварлан тогтоох үр нөлөөтэй.

Хэрэглүүрийг эзэмшдэггүй тал ба тухайн гаргагч байгууллагын хооронд хийгдэж болох гэрээний нөхцлүүд болон гэрээтэй адилтгах хэлцлийн болзлуудтай ижил төсөөтэй гэрээний нөхцөл, болзол бүхий, 17-р параграфт заасан хэрэглүүрийн эзэмшигчтэй хийсэн санхүүгийн бус гэрээг тухайн байгууллага нь дээрх нөхцлийг мөрдөх зорилгоор харгалзан үзэхгүй. Хэрэв байгууллага нь дээрх нөхцөл хангагдсан эсэхийг тодорхойлж чадахгүй бол уг хэрэглүүрийг өмчийн хэрэглүүр гэж ангилахгүй.

*Байгууллагыг зөвхөн татан буулгах үед түүний цэвэр хөрөнгөөс хувь тэнцүүлэн нөгөө талдаа өгөх үүргийг тухайн байгууллагад хүлээлгэдэг хэрэглүүр ба буцаах эрхтэй хэрэглүүрийн дахин ангилал*

19. Хэрэглүүр нь 15, 16-р параграф эсвэл 17, 18-р параграфт заасан бүх шинжүүдтэй бөгөөд нөхцлүүдийг хангасан өдрөөс эхлэн байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийг эдгээр параграфуудын дагуу өмчийн хэрэглүүр гэж ангилна. Уг хэрэглүүр нь эдгээр параграфуудад заасан бүх шинжүүдтэй байхаа больсон буюу нөхцлүүдийг хангахгүй болсон өдрөөс

эхлэн байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийг дахин ангилна. Жишээлбэл; байгууллага нь өөрийн гаргасан, буцаах эрхгүй бүх хэрэглүүрийг эргэлтээс гаргасан ба эргэлтэнд үлдсэн, буцаах эрхтэй аливаа хэрэглүүр нь 15, 16-р параграфуудад заасан бүх шинжүүдтэй бөгөөд нөхцлүүдийг хангаж байвал тухайн байгууллага нь буцаах эрхгүй хэрэглүүрийг эргэлтээс гаргасан өдрөөс эхлэн уг буцаах эрхтэй хэрэглүүрийг өмчийн хэрэглүүр гэж дахин ангилна.

20. Байгууллага нь 19-р параграфын дагуу хийх хэрэглүүрийн дахин ангилалыг дараах байдлаар тайлагнана:

- (а) Хэрэглүүр нь 15, 16-р параграф эсвэл 17, 18-р параграфуудад заасан бүх шинжүүдтэй байхаа больсон буюу нөхцлүүдийг хангахгүй болсон өдрөөс эхлэн байгууллага нь өмчийн хэрэглүүрийг санхүүгийн өр төлбөр гэж дахин ангилна. Санхүүгийн өр төлбөрийг тухайн дахин ангиллын өдрөөрх уг хэрэглүүрийн бодит үнэ цэнээр хэмжинэ. Байгууллага нь тухайн дахин ангиллын өдрөөрх өмчийн хэрэглүүрийн дансны үнэ ба санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийн хоорондох аливаа зөрүүг өмчид хүлээн зөвшөөрнө.
- (б) Хэрэглүүр нь 15, 16-р параграф эсвэл 17, 18-р параграфуудад заасан бүх шинжүүдтэй бөгөөд нөхцлүүдийг хангасан өдрөөс эхлэн байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийг өмчийн хэрэглүүр гэж дахин ангилна. Өмчийн хэрэглүүрийг тухайн дахин ангиллын өдрөөрх уг санхүүгийн өр төлбөрийн дансны үнээр хэмжинэ.

*Мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг өгөх гэрээний үүрэггүй байх (14(а) параграф)*

21. 15, 16-р параграф эсвэл 17, 18-р параграфуудад заасан нөхцлүүдийг гажих тохиолдолд санхүүгийн өр төлбөрийг өмчийн хэрэглүүрээс ялгах гол шинж нь санхүүгийн хэрэглүүрийн нэг тал (гаргагч) мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг нөгөө талдаа (эзэмшигч) өгөх эсвэл уг гаргагчид тааламжгүй байх нөхцлөөр санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг тухайн эзэмшигчтэй солилцох гэрээний үүрэгтэй байх явдал юм. Өмчийн хэрэглүүрийн эзэмшигч нь зарласан аливаа ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтаас, эсвэл цэвэр хөрөнгө/өмчийн хуваарилалтаас хувь тэнцүүлэн авах эрхтэй байж болох боловч мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг нөгөө талдаа өгөхийг гаргагчаас шаардахгүй учраас тухайн гаргагч нь ийм хуваарилалт хийх гэрээний үүрэг хүлээхгүй.

22. Санхүүгийн хэрэглүүрийн хуулийн хэлбэр биш, харин мөн чанар нь тухайн байгууллагын санхүүгийн байдлын тайлан дахь түүний ангиллыг тогтоодог. Мөн чанар ба хуулийн хэлбэр нь ерөнхийдөө нийцдэг боловч байнга тийм байдаггүй. Зарим санхүүгийн хэрэглүүр нь хуулийн хэлбэрийн хувьд өмч байх боловч мөн чанарын хувьд өр төлбөр байдаг. Өөр зарим нь өмчийн хэрэглүүртэй холбоотой шинжүүд болон санхүүгийн өр төлбөртэй холбоотой шинжүүдийн аль алиныг агуулсан байж болно. Жишээлбэл;

- (а) Тогтмол буюу тодорхойлж болох дүнгээр ирээдүйн тогтсон буюу тодорхойлж болох хугацаанд тухайн гаргагч заавал эргэлтээс гаргахаар заасан эсвэл тухайлсан нэг өдөр буюу түүнээс хойшхи хугацаанд тогтмол буюу тодорхойлж болох дүнгээр уг хэрэглүүрийг эргэлтээс гаргахыг тухайн гаргагчаас шаардах эрхийг эзэмшигчдээ олгодог давуу эрхтэй хувьцаа нь санхүүгийн өр төлбөр юм.
- (б) Тухайн гаргагчид мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгөөр буцаан өгөх эрхийг эзэмшигчдээ олгодог бөгөөд 15, 16-р параграф эсвэл 17, 18-р параграфуудын дагуу өмчийн хэрэглүүр гэж ангилсан хэрэглүүрүүдээс бусад санхүүгийн хэрэглүүр ('буцаах эрхтэй хэрэглүүр') нь санхүүгийн өр төлбөр юм. Мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийн дүнг нь өсөх эсвэл буурах боломжтой индекс болон бусад зүйлсэд үндэслэн тодорхойлдог байлаа ч гэсэн уг санхүүгийн хэрэглүүр нь санхүүгийн өр төлбөр болно. 15, 16-р параграф эсвэл 17, 18-р параграфуудын дагуу өмчийн хэрэглүүр гэж ангилсан хэрэглүүрүүдээс бусад хэрэглүүрийг түүний гаргагчид мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгөөр буцаан өгөх сонголт тухайн эзэмшигчид байх нь уг буцаах эрхтэй хэрэглүүр санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангана гэсэн үг юм. Жишээлбэл; 15, 16-р параграф эсвэл 17, 18-р параграфуудын дагуу өмчийн хэрэглүүр гэж ангилсан хэрэглүүрүүдээс бусад хэрэглүүрийн хувьд нээлттэй хамтын сан, нэгжийн итгэлцлийн сан, нөхөрлөл, зарим хоршоо зэрэг байгууллагууд нь тухайн гаргагч дахь хувь оролцоогоо хүссэн үедээ мөнгөөр эргэлтээс гаргах эрхийг өөрсдийн эзэмшигчид буюу гишүүдэд олгож болох бөгөөд ингэснээр тэдгээр эзэмшигчид буюу гишүүдийн хувь оролцоог санхүүгийн өр төлбөр гэж ангилгахад хүргэдэг. Гэвч санхүүгийн өр төлбөр гэсэн ангилал нь хувь нийлүүлсэн цэвэр хөрөнгө/өмчгүй байгууллагын (зарим хамтын сан, итгэлцлийн сан гэх мэт, Үлгэрчилсэн Жишээ 7-г үзнэ үү) санхүүгийн тайланд "эзэмшигчдэд хамаарах цэвэр хөрөнгө", "эзэмшигчдэд хамаарах цэвэр хөрөнгийн өөрчлөлт" гэх мэт нэр тодорхойлолт ашиглахыг, эсвэл цэвэр хөрөнгө/өмчийн тодорхойлолтыг хангах нөөц, уг тодорхойлолтыг хангахгүй, буцаах эрхтэй хэрэглүүр (Үлгэрчилсэн Жишээ 8-ыг үзнэ үү) зэргээс бүрдэх гишүүдийн нийт хувь оролцоог харуулахын тулд нэмэлт тодруулга ашиглахыг хязгаарлахгүй.
23. 15, 16-р параграф буюу 17, 18-р параграфуудын дагуу өмчийн хэрэглүүр гэж ангилсан хэрэглүүрүүдээс бусад хэрэглүүрийн хувьд байгууллага нь гэрээний үүргээ биелүүлэхийн тулд мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгө өгөхөөс татгалзах нөхцөлт бус эрхгүй бол уг үүрэг нь санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангана. Жишээлбэл:
- (а) Гадаад валютын гүйлгээний хязгаарлалт, зохицуулах эрх байгууллагаас төлбөр хийх зөвшөөрөл авах шаардлага гэх мэт гэрээний үүргээ биелүүлэх уг байгууллагын чадвар боломжинд тавигдах хязгаарлалт нь тухайн хэрэглүүрийн дагуу байгууллагын хүлээх гэрээний үүрэг эсвэл эзэмшигчийн гэрээний эрхийг үгүйсгэхгүй.

(б) Тухайн байгууллага нь мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгө өгөхөөс зайлсхийх нөхцөлт бус эрхгүй учраас нөгөө тал эргэлтээс гаргах өөрийн эрхийг хэрэгжүүлэх эсэхээс нөхцөлт хамааралтай гэрээний үүрэг нь санхүүгийн өр төлбөр болно.

24. Мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг өгөх гэрээний үүргийг тодорхой заагаагүй санхүүгийн хэрэглүүр нь өөрийн нөхцөл, болзлоор дамжуулан уг үүргийг шууд бусаар тогтоосон байж болох юм. Жишээлбэл:

(а) Санхүүгийн хэрэглүүр нь тухайн байгууллага хуваарилалтыг олгоогүй эсвэл уг хэрэглүүрийг эргэлтээс гаргаагүй зөвхөн тийм тохиолдолд барагдуулах шаардлагатай санхүүгийн бус үүргийг агуулсан байж болох юм. Байгууллага нь уг санхүүгийн бус үүргийг барагдуулсан зөвхөн тийм тохиолдолд мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг шилжүүлэхээс зайлсхийж чадах бол тухайн санхүүгийн хэрэглүүр нь санхүүгийн өр төлбөр болно.

(б) Санхүүгийн хэрэглүүрийг барагдуулснаар тухайн байгууллага нь доорх зүйлсийн аль нэгийг өгөхөөр бол уг санхүүгийн хэрэглүүр нь санхүүгийн өр төлбөр болох юм:

(i) Мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгө; эсвэл

(ii) Мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийн үнэ цэнээс мэдэгдэхүйц их үнэ цэнэ бүхий өөрийн хувьцаа.

Хэдийгээр байгууллага нь мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг өгөх гэрээний тодорхой үүрэггүй боловч хувьцаагаар барагдуулах хувилбарын үнэ цэнэ нь тухайн байгууллага мөнгөөр барагдуулахтай адил байна. Аль ч тохиолдолд эзэмшигч нь мөнгөөр барагдуулах сонголттой наад зах нь тэнцүү дүнг хүлээн авах баталгаагаар мөн чанарын хувьд хангагдсан байдаг (25-р параграфыг үзнэ үү).

*Байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрээр барагдуулалт (14(б) параграф)*

25. Гэрээ нь тухайн байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрийг хүлээн авах эсвэл өгөхөд хүргэдэг байж болох учраас дангаараа өмчийн хэрэглүүр болохгүй юм. Тухайн байгууллагын хүлээн авах эсвэл өгөх өөрийн өмчийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ нь уг гэрээний эрх буюу үүргийн дүнтэй тэнцүү байх тул үүнээс хамааран тоо нь хувьсан өөрчлөгдөх өөрийн хувьцаа буюу бусад өмчийн хэрэглүүрийг байгууллага нь хүлээн авах эсвэл өгөх гэрээний эрх буюу үүрэгтэй байж болно. Ийм гэрээний эрх, үүрэг нь тогтмол дүнтэй эсвэл тухайн байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрийн зах зээлийн үнээс бусад үзүүлэлтийн (жишээ нь; хүүний түвшин, бараа бүтээгдэхүүний үнэ, санхүүгийн хэрэглүүрийн үнэ) өөрчлөлтөөс бүрэн буюу хэсэгчлэн хамаарч хувьсан өөрчлөгдөх дүнтэй байж болно. Ийм хувьсах дүнтэй гэрээний хоёр жишээг дурдвал: (а) үнэ цэнийн хувьд 100ТН-тэй тэнцүү байх тухайн байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрийг өгөх гэрээ; (б) үнэ цэнийн хувьд 100 унци алтны үнэтэй тэнцүү байх тухайн байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрийг өгөх гэрээ. Хэдийгээр тухайн байгууллага нь өөрийн өмчийн хэрэглүүрийг өгснөөр



гэрээг барагдуулах ёстой буюу боломжтой боловч ийм гэрээ нь уг байгууллагын санхүүгийн өр төлбөр болно. Байгууллага нь ийм гэрээг барагдуулах хэрэгсэл болгон өөрийн тогтмол бус тооны өмчийн хэрэглүүрийг ашигладаг тул уг гэрээг өмчийн хэрэглүүр гэж үзэхгүй. Иймээс энэхүү гэрээ нь тухайн байгууллагын бүх өр төлбөрийг хассаны дараа түүний хөрөнгөнд үлдэх хувь оролцоог илэрхийлэхгүй.

26. 27-р параграфт зааснаас бусад тохиолдолд тогтмол дүн бүхий мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийн хариуд өөрийн тогтмол тоо ширхэгтэй өмчийн хэрэглүүрийг өгснөөр (авснаар) тухайн байгууллага барагдуулах гэрээ нь өмчийн хэрэглүүр юм. Жишээлбэл; тухайн байгууллагын тодорхой тооны хувьцааг тогтмол үнээр эсвэл бондыг тодорхой тогтоосон үндсэн дүнгээр худалдан авах эрхийг нөгөө талдаа олгодог гаргасан хувьцааны опцион нь өмчийн хэрэглүүр юм. Төлөх эсвэл хүлээн авах мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийн дүнд нөлөөлөхгүй зах зээлийн хүүний түвшний өөрчлөлтөөс үүссэн гэрээний бодит үнэ цэнийн өөрчлөлт эсвэл гэрээний барагдуулалтаар хүлээн авах буюу өгөх өмчийн хэрэглүүрийн тоо нь тухайн гэрээ өмчийн хэрэглүүр болоход саад учруулахгүй. Хүлээн авсан аливаа төлбөрийг (тухайн байгууллагын өөрийн хувьцаанд хамаарах гаргасан опцион буюу баталгааны хувьд хүлээн авсан урамшуулал гэх мэт) цэвэр хөрөнгө/өмч дээр шууд нэмнэ. Харин төлсөн аливаа төлбөрийг (худалдан авсан опционд төлсөн урамшуулал гэх мэт) цэвэр хөрөнгө/өмчөөс шууд хасна. Өмчийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөхгүй.
27. Гэрээний барагдуулалтаар байгууллагын хүлээн авах эсвэл өгөх тухайн байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүр нь 15 ба 16-р параграфуудад заасан бүх шинжүүдтэй бөгөөд нөхцлүүдийг хангасан буцаах эрхтэй санхүүгийн хэрэглүүр эсвэл 17 ба 18-р параграфуудад заасан бүх шинжүүдтэй бөгөөд нөхцлүүдийг хангаж, зөвхөн татан буугдах үед тухайн байгууллагын цэвэр хөрөнгөөс хувь тэнцүүлэн нөгөө талд өгөх үүргийг уг байгууллагад хүлээлгэдэг хэрэглүүр байвал энэхүү гэрээ нь санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөр болно. Үүнд: тогтмол дүн бүхий мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийн хариуд ийм хэрэглүүрийг тогтмол тоо хэмжээгээр авах буюу өгөх байдлаар тухайн байгууллагын барагдуулж болох гэрээ хамаарна.
28. 15, 16-р параграф эсвэл 17, 18-р параграфуудад заасан нөхцлүүдийг гажих тохиолдолд өөрийн өмчийн хэрэглүүрийг мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгөөр худалдан авах тухайн байгууллагын үүргийг агуулсан гэрээ нь уг эргэлтээс гаргах дүнгийн (жишээлбэл; буцаан худалдан авах форвард үнэ, опционыг хэрэгжүүлэх үнэ буюу эргэлтээс гаргах бусад дүнгийн) өнөөгийн үнэ цэнийн хэмжээгээр санхүүгийн өр төлбөр үүсэхэд хүргэнэ. Хэдийгээр уг гэрээ нь өөрөө өмчийн хэрэглүүр байсан ч гэсэн ийм нөхцөл байдал үүсдэг. Форвард гэрээний дагуу өөрийн өмчийн хэрэглүүрийг мөнгөөр худалдан авах уг байгууллагын үүрэг нь үүний нэг жишээ болно. Санхүүгийн өр төлбөрийг УСНББОУС 29-ийн дагуу эхлээд хүлээн зөвшөөрдөг тохиолдолд түүний бодит үнэ цэнийг

(эргэлтээс гаргах дүнгийн өнөөгийн үнэ цэнийг) цэвэр хөрөнгө/өмчөөс дахин ангилдаг. Уг санхүүгийн өр төлбөрийг дараа нь УСНББОУС 29-ийн дагуу хэмжинэ. Хэрэв хөрөнгө өгөөгүй байхад тухайн гэрээний хугацаа дууссан бол уг санхүүгийн өр төлбөрийн дансны үнээр нь цэвэр хөрөнгө/өмчид дахин ангилна. Хэдийгээр өөрийн өмчийн хэрэглүүрийг худалдан авах тухайн байгууллагын гэрээний үүрэг нь нөгөө тал эргэлтээс гаргах өөрийн эрхийг хэрэгжүүлэх эсэхээс (жишээ нь; байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрийг тухайн аж ахуйн нэгжид тогтмол үнээр борлуулах эрхийг нөгөө талд олгодог, гаргасан буцаах эрхтэй опцион) нөхцөлт хамааралтай боловч уг худалдан авах гэрээний үүрэг нь тэрхүү эргэлтээс гаргах дүнгийн өнөөгийн үнэ цэнийн хэмжээгээр санхүүгийн өр төлбөр үүсэхэд хүргэнэ.

29. Тогтмол бус дүн бүхий мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийн хариуд байгууллага өөрийн тогтмол тоо ширхэгтэй өмчийн хэрэглүүрийг өгөх буюу авах байдлаар барагдуулах гэрээ нь санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөр болно. 100 баррел газрын тосны үнэ цэнэтэй тэнцүү байхаар тооцоолсон мөнгөний хариуд байгууллага өөрийн 100 ширхэг өмчийн хэрэглүүрийг өгөх гэрээ нь үүний жишээ болох юм.

*Төлбөр барагдуулалтын болзошгүй нөхцлүүд*

30. Санхүүгийн хэрэглүүр нь үнэт цаасны зах зээлийн индексийн өөрчлөлт, хэрэглэгчийн үнийн индекс, хүүний түвшин, татвар ногдуулах шаардлагууд эсвэл гаргагчийн ирээдүйн орлого, цэвэр ашиг буюу алдагдал, өр ба өмчийн харьцаа гэх мэт уг хэрэглүүрийн гаргагч ба эзэмшигчийн аль алины хяналтанд үл хамаарах ирээдүйн тодорхой бус үйл явдлууд гарч тохиолдсон буюу гарч тохиолдоогүй үед (эсвэл тодорхой бус нөхцөл байдлуудын үр дүнд) мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг өгөх, хэрэв санхүүгийн өр төлбөр байсан бол төлөх байсан тийм арга замаар барагдуулахыг тухайн байгууллагаас шаарддаг байж болох юм. Ийм хэрэглүүрийн гаргагч нь мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг өгөхөөс (хэрэв санхүүгийн өр төлбөр байсан бол төлөх байсан тийм арга замаар барагдуулахаас) зайлсхийх нөхцөлт бус эрхгүй байдаг. Ийм учраас энэ нь доор дурдснаас бусад тохиолдолд уг гаргагчийн санхүүгийн өр төлбөр болно:
- (a) Мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгөөр төлбөр барагдуулахыг (хэрэв санхүүгийн өр төлбөр байсан бол төлөх байсан тийм арга замаар барагдуулахыг) шаардаж болох уг төлбөр барагдуулалтын зарим болзошгүй нөхцөл нь бодитой бус байх;
  - (б) Гаргагч тал зөвхөн татан буугдах үед үүргийг мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгөөр барагдуулахыг (хэрэв санхүүгийн өр төлбөр байсан бол төлөх байсан тийм арга замаар барагдуулахыг) тухайн гаргагчаас шаардаж болох; эсвэл
  - (в) Тухайн хэрэглүүр нь 15 ба 16-р параграфуудад заасан бүх шинжүүдтэй бөгөөд нөхцлүүдийг хангадаг.

*Барагдуулалтын сонголтууд*

31. **Үүсмэл санхүүгийн хэрэглүүр нь түүнийг хэрхэн барагдуулах талаар сонголт хийх боломжийг аль нэг талд олгодог (жишээлбэл; гаргагч эсвэл эзэмшигч нь цэвэр дүнгээр нь мөнгөөр, эсвэл хувьцаагаа мөнгөөр солилцсоноор барагдуулах сонголт хийж болно) бөгөөд барагдуулалтын бүх хувилбарууд нь уг хэрэглүүрийг өмчийн хэрэглүүр болгох үр дүнтэй байхаас бусад тохиолдолд энэ нь санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөр болно.**
32. Төлбөр барагдуулах сонголт бүхий үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн нэг жишээ нь санхүүгийн өр төлбөр тухайлбал, хувьцааны опцион юм. Энэ тохиолдолд гаргагч нь цэвэр дүнгээр нь мөнгөөр барагдуулах эсвэл өөрийн хувьцааг мөнгөөр солилцох сонголт хийж болно. Үүнтэй адилаар, тухайн байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрийн хариуд санхүүгийн бус зүйл худалдан авах буюу борлуулах зарим гэрээг уг санхүүгийн бус зүйлийг өгснөөр, эсвэл цэвэр дүнгээр нь мөнгө буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулж болох тул тийм гэрээ нь энэ Стандартын цар хүрээнд хамаарна (4-6-р параграфуудыг үзнэ үү). Ийм гэрээ нь өмчийн хэрэглүүр биш, харин санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөр болно.

**Нийлмэл санхүүгийн хэрэглүүр (Мөн МЗУ55-МЗУ60-р параграфууд болон Үлгэрчилсэн жишээ 9-12-ыг үзнэ үү)**

33. **Үүсмэл бус санхүүгийн хэрэглүүр нь өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгийн аль алиныг агуулж буй эсэхийг тодорхойлохын тулд түүний гаргагч нь уг санхүүгийн хэрэглүүрийн нөхцлүүдийг үнэлж үзнэ. Ийм бүрэлдэхүүн хэсгүүдийг 13-р параграфын дагуу санхүүгийн өр төлбөр, санхүүгийн хөрөнгө эсвэл өмчийн хэрэглүүр гэж тус тусад нь ангилна.**
34. Байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг (а) тухайн байгууллагад санхүүгийн өр төлбөр үүсгэдэг, (б) уг хэрэглүүрийг тухайн байгууллагын өмчийн хэрэглүүрт хөрвүүлэх сонголтыг эзэмшигчдээ олгодог гэдгээр тус тусад нь хүлээн зөвшөөрнө. Жишээлбэл; эзэмшигч зүгээс тухайн байгууллагын тогтмол тоо ширхэгтэй энгийн хувьцаанд хөрвүүлэх боломжтой бонд буюу үүнтэй ижил төсөөтэй хэрэглүүр нь нийлмэл санхүүгийн хэрэглүүр юм. Харин тухайн байгууллагын зүгээс авч үзвэл, ийм хэрэглүүр нь санхүүгийн өр төлбөр (мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг өгөх гэрээ хэлцэл) ба өмчийн хэрэглүүр (тодорхой заасан хугацаанд тухайн байгууллагын тогтмол тоо ширхэгтэй энгийн хувьцаанд хөрвүүлэх эрхийг эзэмшигчдээ олгодог дуудах опцион) гэсэн хоёр бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Ийм хэрэглүүрийг гаргах эдийн засгийн үр нөлөө нь эрт барагдуулах нөхцөл бүхий өрийн хэрэглүүрийг энгийн хувьцаа худалдан авах баталгааны хамт гаргахтай, эсвэл хувьцаа худалдаж авах салгах боломжтой баталгаа бүхий өрийн хэрэглүүрийг гаргахтай үндсэндээ ижил юм. Иймээс

байгууллага нь аливаа тохиолдолд уг өр төлбөр ба өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдийг өөрийн санхүүгийн байдлын тайландаа тусад нь толилуулна.

35. Хэдийгээр опционыг хэрэгжүүлснээр зарим эзэмшигчдэд эдийн засгийн давуу тал олгох нь илэрхий байж болох боловч хөрвүүлэх опционыг хэрэгжүүлэх магадлал өөрчлөгдсөний үр дүнд уг хөрвөх хэрэглүүрийн өр төлбөрийн болон өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдийн ангиллыг өөрчлөхгүй. Тухайлбал; хөрвүүлэлтээс үүсэх татварын үр дагавар нь эзэмшигч бүрд харилцан адилгүй байж болох тул эзэмшигчид нь хүлээгдэж байснаас ямагт өөр үйлдэл хийж болох юм. Түүнчлэн, хөрвүүлэх магадлал нь нэг цаг хугацаанаас нөгөө цаг хугацаанд өөрчлөгдөж байдаг. Ирээдүйд төлбөрүүдийг хийх тухайн байгууллагын гэрээний үүрэг нь уг хэрэглүүрийн хөрвүүлэлт, хугацаа дуусалт буюу бусад зарим ажил гүйлгээгээр барагдаж дуусах хүртэл хэвээр үлдэнэ.
36. УСНББОУС 29 нь санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн хэмжилтийг тодорхойлдог. Өмчийн хэрэглүүр нь бүх өр төлбөрийг хассаны дараа байгууллагын хөрөнгөнд үлдэх хувь оролцоог илэрхийлдэг хэрэглүүр юм. Иймээс нийлмэл санхүүгийн хэрэглүүрийн анхны дансны үнийг түүний бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваарилах үед тухайн хэрэглүүрт бүхэлд нь хамаарах бодит үнэ цэнээс өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсгийн хувьд тусад нь тодорхойлсон дүнг хассаны дараах уг үлдэх дүнгээр цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлно. Тухайн нийлмэл санхүүгийн хэрэглүүрт агуулагдаж буй аливаа үүсмэл хэсгүүд (дуудах опцион гэх мэт) нь цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгийг (өмчид хөрвөх опцион гэх мэт) бүрдүүлж байхаас бусад тохиолдолд тэдгээрийг өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсэгт хамааруулна. Анхны хүлээн зөвшөөрөлтөөр өр төлбөрийн болон цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваарилсан дансны үнүүдийн нийлбэр нь бүхэлдээ уг хэрэглүүрт хамааруулах байсан бодит үнэ цэнэтэй ямагт тэнцүү байна. Хэрэглүүрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тус тусад нь анх хүлээн зөвшөөрөх үед ямар нэгэн олз, гарз үүсэхгүй.
37. 36-р параграфт заасан арга хандлагыг хэрэглэхдээ, энгийн хувьцаанд хөрвөх боломжтой бонд гаргагч нь холбогдох цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсэггүй ижил төсөөтэй өр төлбөрийн (үүн дотроо аливаа дагалдах өмчийн бус үүсмэл хэсгүүдийн) бодит үнэ цэнийг хэмжсэнээр тухайн өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсгийн дансны үнийг эхлээд тодорхойлно. Тухайн нийлмэл санхүүгийн хэрэглүүрт бүхэлд нь хамаарах бодит үнэ цэнээс энэхүү санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийг хассанаар уг хэрэглүүрийг энгийн хувьцаанд хөрвүүлэх опционоор илэрхийлэгдэх өмчийн хэрэглүүрийн дансны үнийг дараа нь тодорхойлно.

### **Халаасны хувьцаа (Мөн МЗУ61-р параграфыг үзнэ үү)**

38. **Хэрэв байгууллага нь өөрийн өмчийн хэрэглүүрүүдийг буцаан худалдаж авсан бол тэдгээр хэрэглүүр (“халаасны хувьцаа”)-ийг цэвэр хөрөнгө/өмчөөс хасна. Байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрийг худалдан авах, борлуулах, гаргах, хүчингүй болгох үед**

**ямар нэг олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөхгүй. Тухайн байгууллага эсвэл эдийн засгийн нэгдмэл байгууллагын бусад гишүүд нь ийм халаасны хувьцааг худалдан авч, эзэмшиж болно. Төлсөн буюу хүлээн авсан төлбөрийг цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрнө.**

39. Эзэмшиж буй халаасны хувьцааны дүнг УСНББОУС 1, *Санхүүгийн Тайлангийн Толилуулга*-ын дагуу санхүүгийн байдлын тайланд эсвэл тэмдэглэл хэсэгт тусад нь тодруулна. Хэрэв байгууллага нь өөрийн өмчийн хэрэглүүрийг холбоотой талуудаас буцаан худалдаж авсан бол УСНББОУС 20, *Холбоотой Талуудын Тодруулга*-ын дагуу тодруулгыг хийнэ.

### **Хүү, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт, олз ба гарз (Мөн МЗУ62-р параграфыг үзнэ үү)**

40. Санхүүгийн хэрэглүүртэй эсвэл түүний санхүүгийн өр төлбөр гэж ангилсан бүрэлдэхүүн хэсэгтэй холбоотой хүү, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт, гарз, олзыг ашиг, алдагдалд орлого эсвэл зардал гэж хүлээн зөвшөөрнө. Тухайн байгууллага нь өмчийн хэрэглүүр эзэмшигчдэд олгох хуваарилалтыг цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрнө. Цэвэр хөрөнгө/өмчийн ажил гүйлгээтэй холбоотой ажил гүйлгээний зардлыг цэвэр хөрөнгө/өмчийн бууралт байдлаар тайлагнана.
- 40А. Өмчийн хэрэглүүр эзэмшигчдэд олгох хуваарилалт болон өмчийн ажил гүйлгээнд хамаарах ажил гүйлгээний зардалтай холбоотой орлогын албан татварыг тухайн орлогын албан татварыг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартуудын дагуу тайлагнана.
41. Санхүүгийн хэрэглүүрийг санхүүгийн өр төлбөр эсвэл өмчийн хэрэглүүр гэж ангилах ангилал нь тухайн хэрэглүүртэй холбоотой хүү, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт, гарз, олзыг ашиг, алдагдалд орлого эсвэл зардал байдлаар хүлээн зөвшөөрөх эсэхийг тодорхойлдог. Иймээс өр төлбөр гэж бүхэлд нь хүлээн зөвшөөрсөн хувьцааны ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг бондын хүүг бүртгэдэгтэй адилаар зардал гэж хүлээн зөвшөөрнө. Үүнтэй адилаар, санхүүгийн өр төлбөрийн эргэлтээс гаргалт буюу дахин санхүүжүүлэлттэй холбоотой олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Харин өмчийн хэрэглүүрийн эргэлтээс гаргалт буюу дахин санхүүжүүлэлтийг цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт байдлаар хүлээн зөвшөөрнө. Өмчийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөхгүй.
42. Байгууллага нь өөрийн өмчийн хэрэглүүрийг гаргах буюу худалдан авахдаа ихэвчлэн янз бүрийн зардлууд гаргадаг. Ийм зардалд бүртгүүлэлт ба бусад зохицуулалтын хураамж, хуулийн, нягтлан бодох бүртгэлийн болон бусад мэргэжлийн зөвлөгчид төлсөн төлбөр, хэвлүүлэх зардал, тэмдэгтийн хураамж хамаарна. Цэвэр хөрөнгө/өмчийн ажил

гүйлгээтэй холбоотой ажил гүйлгээний зардал нь хэрэв уг өмчийн ажил гүйлгээ гараагүй бол зайлсхийх боломжтой бөгөөд тухайн цэвэр хөрөнгө/өмчийн ажил гүйлгээнд шууд хамааруулж болох өсөн нэмэгдэх зардал байх тэр хэмжээгээр түүнийг цэвэр хөрөнгө/өмчийн бууралт байдлаар тайлагнана. Хүчингүй болсон цэвэр хөрөнгө/өмчийн ажил гүйлгээний зардлыг зардал гэж хүлээн зөвшөөрнө.

43. Нийлмэл санхүүгийн хэрэглүүрийн гаргалттай холбоотой ажил гүйлгээний зардлыг харгалзах орлогын хуваарилалттай шууд хамааралтайгаар уг хэрэглүүрийн өр төлбөрийн болон цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваарилна. Нэгээс олон ажил гүйлгээнд хамаарах ажил гүйлгээний зардлыг ижил төсөөтэй ажил гүйлгээний хувьд ул үндэслэлтэй ба тохиромжтой байх тийм хуваарилалтын суурийг ашиглан тэдгээр ажил гүйлгээнд хуваарилна.
44. Тухайн тайлант үед цэвэр хөрөнгө/өмчийн бууралт байдлаар тайлагнасан ажил гүйлгээний зардлын дүнг УСНББОУС 1-ийн дагуу тусад нь тодруулна.
45. Зардал гэж ангилсан ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг санхүүгийн үр дүнгийн тайланд бусад өр төлбөрийн хүүний хамтаар эсвэл тусдаа мөрийн зүйл байдлаар толилуулна. Хүү, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтын тодруулга нь энэ Стандартын шаардлагуудаас гадна УСНББОУС 1 ба УСНББОУС 30-ын шаардлагуудад захирагддаг. Татвараас хасагдах зардал болох эсэх гэх мэт асуудлуудын хувьд хүү, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт нь хоорондоо ялгаатай байдгаас шалтгаалан зарим тохиолдолд тэдгээрийг санхүүгийн үр дүнгийн тайланд тус тусад нь тодруулах хэрэгтэй байдаг.
46. Мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийн (22(б) параграфыг үзнэ үү) хариуд тухайн байгууллагын хөрөнгөнд үлдэх хувь оролцоотой болох тийм эрхийг агуулсан хэрэглүүрт хамааралтай байсан ч гэсэн санхүүгийн өр төлбөрийн дансны үнийн өөрчлөлттэй холбоотой олз, гарзыг ашиг, алдагдалд орлого эсвэл зардал гэж хүлээн зөвшөөрнө. Ийм хэрэглүүрийн дахин хэмжилтээс үүссэн аливаа олз буюу гарз нь тухайн байгууллагын үр дүнг тайлбарлахад хамааралтай байх тохиолдолд уг байгууллага нь УСНББОУС 1-ийн дагуу түүнийг санхүүгийн үр дүнгийн тайланд тусад нь толилуулна.

### **Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийг харилцан суутгаж, цэвэр дүн гаргалт (Мөн МЗУ63 ба МЗУ64-р параграфыг үзнэ үү)**

47. **Зөвхөн дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийг харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах бөгөөд уг цэвэр дүнг санхүүгийн байдлын тайланд толилуулна:**

- (а) Байгууллага нь одоогоор уг хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг харилцан суутгаж, цэвэр дүн гаргах хууль ёсны хүчин төгөлдөр эрхтэй байх; ба
- (б) Байгууллага нь цэвэр дүнгээр барагдуулах эсвэл хөрөнгийг борлуулж, өр төлбөрийг үүнтэй нэгэн зэрэг барагдуулах төлөвлөгөөтэй байх.

**Үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаагүй санхүүгийн хөрөнгийн шилжүүлэлтийг тайлагнахдаа тухайн байгууллага нь уг шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөрийг харилцан суутгаж, цэвэр дүнг гаргахгүй (УСНББОУС 29-ийн 38-р параграфыг үзнэ үү).**

- 48. Хоёр буюу хэд хэдэн тусдаа санхүүгийн хэрэглүүрийг барагдуулснаар үүсэх байгууллагын ирээдүйн хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг тусгах тийм байдлаар санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийг цэвэр сууриар толилуулахыг энэхүү Стандартаар шаарддаг. Байгууллага нь нэг цэвэр дүнгээр төлбөрийг хүлээн авах буюу барагдуулах эрхтэй бөгөөд ингэж цэвэр дүнгээр хийхээр төлөвлөж байгаа тохиолдолд энэ нь үнэн хэрэгтээ зөвхөн нэг санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөртэй адил байна. Бусад тохиолдолд санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийг тэдгээрийн шинж чанарт нийцүүлэн тухайн байгууллагын нөөц буюу үүрэг байдлаар нэг нэгнээс нь тусдаа толилуулдаг.
- 49. Хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгө ба хүлээн зөвшөөрсөн санхүүгийн өр төлбөрийг харилцан суутгаж, цэвэр дүнгээр толилуулах нь санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлтөөс ялгаатай юм. Харилцан суутгаж, цэвэр дүн гаргалт нь олз буюу гарз хүлээн зөвшөөрөхөд хүргэхгүй боловч санхүүгийн хэрэглүүрийн үл хүлээн зөвшөөрөлт нь зөвхөн өмнө хүлээн зөвшөөрсөн зүйлийг тухайн санхүүгийн байдлын тайлангаас хасах төдийгүй олз, гарзыг хүлээн зөвшөөрөхөд хүргэж болох юм.
- 50. Харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах эрх гэдэг нь зээлдүүлэгчид төлөх дүнг бүгдийг эсвэл түүний хэсгийг уг зээлдүүлэгчээс авах дүнгээс хасах замаар барагдуулах буюу бусад хэлбэрээр бууруулах гэрээгээр болон бусад байдлаар олгогдсон зээлдэгчийн хууль ёсны эрх юм. Цөөн зарим тохиолдолд зээлдэгчийн харилцан суутгах эрхийг тодорхой заасан гурван талын хэлцэлтэй бол зээлдэгч нь гуравдагч талаас авах дүнг зээлдүүлэгчид төлөх дүнгээс хасах хууль ёсны эрхтэй байж болно. Харилцан суутгах эрх нь хууль ёсны эрх учраас уг эрхийг зөвшөөрөх нөхцөл байдлууд нь улс орон бүрд өөр өөр байж болох бөгөөд талуудын хоорондох харилцаанд хамаарах хууль тогтоомжийг харгалзан үзэх шаардлагатай байдаг.
- 51. Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийг харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах хууль ёсны эрхтэй байх нь санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөртэй холбоотой эрх, үүрэгт нөлөөлөх ба уг байгууллагын зээлийн болон төлбөрийн чадварын эрсдэлд нөлөө үзүүлж болох юм. Гэвч ийм эрхтэй байх нь харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах хангалттай үндэслэл

дангаараа болохгүй. Эрхийг хэрэгжүүлэх буюу үүнтэй нэгэн зэрэг төлбөрийг барагдуулах төлөвлөгөөгүй тохиолдолд тухайн байгууллагын ирээдүйн мөнгөн гүйлгээний дүн болон хугацаанд нөлөө үзүүлэхгүй. Байгууллага нь эрхийг хэрэгжүүлэх буюу үүнтэй нэгэн зэрэг төлбөрийг барагдуулахаар төлөвлөсөн тохиолдолд хөрөнгө, өр төлбөрийг цэвэр дүнгээр толилуулах нь ирээдүйн хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний дүн, хугацаа, түүнчлэн тэдгээр мөнгөн гүйлгээнд учрах эрсдлийг илүү зохистой илэрхийлдэг. Цэвэр дүнгээр барагдуулах хууль ёсны эрхгүй нэг тал эсвэл хоёр тал хоёулаа ингэж цэвэр дүнгээр барагдуулахаар төлөвлөлөө гэхэд тухайн тодорхой санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөртэй холбоотой эрх, үүрэг өөрчлөгдөхгүй хэвээр үлдэх тул ингэж төлөвлөх нь харилцан суутгаж, цэвэр дүн гаргах хангалттай нөхцөл болохгүй.

52. Тодорхой хөрөнгө, өр төлбөрийг барагдуулах талаархи уг байгууллагын төлөвлөгөөнд түүний хэвийн үйл ажиллагааны практик, санхүүгийн зах зээлийн шаардлагууд, цэвэр дүнгээр эсвэл нэгэн зэрэг барагдуулах чадварыг хязгаарлаж болох бусад нөхцөл байдлууд нөлөө үзүүлж болох юм. Байгууллага нь харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах эрхтэй боловч цэвэр дүнгээр барагдуулах буюу хөрөнгийг борлуулах ба үүнтэй нэгэн зэрэг өр төлбөрийг барагдуулахаар төлөвлөөгүй тохиолдолд тухайн байгууллагын зээлийн эрсдэл өртөлтөнд уг эрхийн үзүүлэх үр нөлөөг УСНББОУС 30-ын 42-р параграфын дагуу тодруулна.
53. Хоёр санхүүгийн хэрэглүүрийн нэгэн зэрэг барагдуулалтыг тухайлбал, зохион байгуулалттай санхүүгийн зах зээлд клирингийн төвийн үйл ажиллагаагаар дамжуулан эсвэл гараас гарт хийгдэх арилжаагаар гүйцэтгэж болно. Эдгээр тохиолдолд мөнгөн гүйлгээ нь үнэн хэрэгтээ, нэг цэвэр дүнтэй адил тэнцүү байх бөгөөд зээлийн буюу төлбөрийн чадварын эрсдэл үүсэхгүй. Өөр бусад тохиолдолд байгууллага нь тусдаа дүнгүүдийг хүлээн авах буюу төлснөөр хоёр хэрэглүүрийг барагдуулж болох бөгөөд хөрөнгийн нийт дүнгийн хувьд зээлийн эрсдэлтэй, харин өр төлбөрийн нийт дүнгийн хувьд төлбөрийн чадварын эрсдэлтэй байдаг. Харьцангуй богино хугацаатай байлаа ч гэсэн ийм эрсдэл өртөлт нь мэдэгдэхүйц нөлөөтэй байж болно. Иймээс харгалзах ажил гүйлгээнүүд нэг агшинд гарч тохиолдсон зөвхөн тийм үед санхүүгийн хөрөнгийн борлуулалт ба санхүүгийн өр төлбөрийн барагдуулалт нэгэн зэрэг хийгдсэн гэж үздэг.
54. Дараах тохиолдолд 47-р параграфт заасан нөхцлүүд ерөнхийдөө хангагдахгүй бөгөөд харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах нь ихэвчлэн тохиромжгүй байдаг:
- (а) Дан ганц санхүүгийн хэрэглүүрийн шинжүүдийг гаргахын тулд өөр өөр хэд хэдэн санхүүгийн хэрэглүүрүүдийг ашиглах (“зохиомол хэрэглүүр”);
  - (б) Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр нь нэг ижил анхдагч эрсдэлтэй боловч өөр өөр оролцогч талууд бүхий санхүүгийн хэрэглүүрүүдээс (тухайлбал; форвард гэрээ буюу бусад үүсмэл хэрэглүүрийн багцад хамаарах хөрөнгө, өр төлбөр) үүссэн байх;



- (в) Санхүүгийн буюу бусад хөрөнгийг баталгаагүй санхүүгийн өр төлбөрийн дэнчин болгон барьцаалах;
  - (г) Зээлдэгч нь үүргээ биелүүлэх зорилгоор итгэмжлэгдсэн этгээдэд санхүүгийн хөрөнгийг байршуулсан боловч зээлдүүлэгч нь уг үүргийн барагдуулалт гэж тэдгээр хөрөнгийг хүлээн зөвшөөрөөгүй байх (жишээлбэл; эргэлтээс гаргах сангийн хэлцэл); эсвэл
  - (д) Гарз үүсэхэд хүргэсэн үйл явдлын үр дүнд бий болсон үүрэг нь даатгалын гэрээний дагуу гаргасан нэхэмжлэлээр гуравдагч талаас нөхөгдөхөөр хүлээгдэж байх.
55. Нэг харилцагч талтай санхүүгийн хэрэглүүрийн олон ажил гүйлгээ хийдэг байгууллага нь уг харилцагчтайгаа “цэвэр дүнгээр тооцох мастер хэлцэл” байгуулж болно. Ийм мастер хэлцэл нь аль нэг гэрээг үл биелүүлэх буюу цуцлах үед тухайн мастер хэлцэлд хамаарах бүх санхүүгийн хэрэглүүрүүдийг нэг цэвэр дүнгээр барагдуулах боломж олгодог. Харилцагч өөрийн үүргээ биелүүлэх чадваргүй болоход хүргэх үр дагавартай дампуурал буюу бусад нөхцөл байдлын үед гарзаас хамгаалахын тулд санхүүгийн байгууллагууд ийм хэлцлийг нийтлэг ашигладаг. Цэвэр дүнгээр тооцох мастер хэлцэл нь хэвийн үйл ажиллагааны явцад гарч тохиолдно гэж хүлээхээргүй тийм үл биелүүлэлтийн тусгай тохиолдол буюу бусад нөхцөл байдал бий болсон тэр даруйд хууль ёсоор хүчин төгөлдөр болох, харилцан суутгалтын эрхийг үүсгэх бөгөөд тухайн тодорхой санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийг борлуулах буюу барагдуулахад нөлөөлдөг. Хэрэв 47-р параграфт заасан шалгуур хоёулаа хангагдахгүй бол цэвэр дүнгээр тооцох мастер хэлцэл нь харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах үндэслэл болохгүй. Цэвэр дүнгээр тооцох мастер хэлцэлд хамаарах санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийг харилцан суутгаж, цэвэр дүнг гаргадаггүй тохиолдолд байгууллагын зээлийн эрсдэл өртөлтөнд уг хэлцлийн үзүүлэх үр нөлөөг УСНББОУС 30-ын 42-р параграфын дагуу тодруулна.

## **Шилжилтийн нөхцөл**

- 56. [Хассан]
- 57. [Хассан]
- 58. [Хассан]

## **Хүчин төгөлдөр болох хугацаа**

- 59. Байгууллага нь энэхүү Стандартыг 2013 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2013 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.

60. Байгууллага нь УСНББОУС 29 ба УСНББОУС 30-ыг бас мөрддөг байхаас бусад тохиолдолд энэ Стандартыг 2013 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө мөрдөхгүй.
- 60А. 2015 оны 01 дүгээр сард гаргасан *УСНББОУС 2014-ийн Сайжруулалтууд*-аар 40, 42, 44-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулж, 40А параграфыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2015 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2015 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 60Б. 2015 оны 01 дүгээр сард гаргасан *УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-ийн үр дүнд 56, 57, 58, 61-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед *УСНББОУС 33*-ыг мөрдсөн бол эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.
- 60В. 2015 оны 01 дүгээр сард гаргасан *УСНББОУС 35, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан* ба *УСНББОУС 37, Хамтын Хэлэлцээр*-ийн үр дүнд 3(а), МЗУ53-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь *УСНББОУС 35* ба *УСНББОУС 37*-г мөрдсөн үеэс эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг дагаж мөрдөнө.
- 60Г. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 7, 8-р параграфуудыг хассан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 60Д. 2016 оны 7 дугаар сард гаргасан *УСНББОУС 39, Ажилтны Тэтгэмж*-ийн үр дүнд 3-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн *УСНББОУС 39*-ийг мөрдөнө.

61. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

### **УСНББОУС 15 (2001)-аас татгалзах**

62. Энэ Стандарт болон УСНББОУС 30 нь 2001 онд гаргасан УСНББОУС 15-ыг орлоно. УСНББОУС 28 ба УСНББОУС 30-ыг мөрдөх эсвэл эдгээр стандартууд хүчин төгөлдөр болох хугацааны аль түрүүнд болох өдөр хүртэл УСНББОУС 15 нь мөрдөх боломжтой хэвээр байна.

## Хавсралт А

### Мөрдөх заавар удирдамж

*Энэ Хавсралт нь УСНББОУС 28-ын салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.*

МЗУ1 Энэхүү Мөрдөх Заавар Удирдамж нь Стандартын тодорхой төлөв байдлуудын мөрдөлтийг тайлбарлана.

МЗУ2 Энэ Стандартад санхүүгийн хэрэглүүрийн хүлээн зөвшөөрөлт буюу хэмжилтийг авч үзэхгүй. Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн хэмжилт, хүлээн зөвшөөрөлтийн талаархи шаардлагуудыг УСНББОУС 29-д заасан.

### Цар хүрээ (3-6-р параграф)

*Санхүүгийн баталгааны гэрээ*

МЗУ3. Санхүүгийн баталгааны гэрээ гэдэг нь тухайн зээлдэгч өрийн хэрэглүүрийн анхны нөхцлийн дагуу төлөх ёстой төлбөрөө барагдуулаагүйн улмаас учирсан алдагдлын хувьд уг гэрээг эзэмшигчид нөхөн төлбөр болгон тодорхой төлбөр төлөхийг түүний гаргагчаас шаарддаг гэрээ юм. Засгийн газар янз бүрийн учир шалтгаанаар санхүүгийн баталгаа гаргаж болно. Засгийн газрын бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх тухайлбал, дэд бүтцийн төслүүдийг дэмжих, зогсонги байдлын үед санхүүгийн зах зээлийг тогтворжуулахын тулд санхүүгийн баталгааг ихэвчлэн гаргадаг. Санхүүгийн баталгаа гаргах бүрэн эрхийг засгийн газарт болон улсын секторын байгууллагуудад хууль буюу бусад бүрэн эрхийн дагуу олгож болох юм. Баталгаа нь гэрээний эсвэл гэрээний бус эсэхийг үнэлэхдээ байгууллага нь баталгаа гаргах эрх болон баталгааны жинхэнэ гаргалтыг ялган салгах хэрэгтэй. Хууль буюу бусад бүрэн эрхийн хүрээнд баталгаа гаргах эрх нь гэрээний бус шинжтэй байдаг боловч баталгаа нь гэрээний шинжтэй эсэхийг тодорхойлохын тулд МЗУ20-д заасан зарчмуудыг ашиглан тухайн баталгааны жинхэнэ гаргалтыг үнэлэх хэрэгтэй.

МЗУ4. Гуравдагч талын ашиг тусын төлөө шууд буюу шууд бусаар санхүүгийн баталгаа гаргах нь гэрээ хэлцлийн үр дүнтэй байж болно. Санхүүгийн баталгааг тодорхой нэг талд эсвэл уг хэрэглүүрийн эзэмшигчид гаргаж болох юм. Дараах хоёр жишээг авч үзье:

- Үйлчилгээний концессийн гэрээнд засгийн газар нь үл биелүүлэлт гарсан тохиолдолд зээлийн үндсэн дүн ба хүүний аливаа төлөгдөөгүй үлдэгдлийг хариуцахаа илэрхийлсэн санхүүгийн баталгааг уг ажил гүйлгээний санхүүжүүлэгчид шууд гарган өгч болох юм. Энэ тохиолдолд санхүүгийн баталгааг уг тодорхойлсон талын ашиг тусын төлөө шууд гаргаж байна.
- Авто замын “А” удирдах байгууллага нь улс орны авто замын дэд бүтцийг барих ба засвар үйлчилгээ хийх хариуцлага хүлээдэг. Тус

байгууллага нь урт хугацаат бонд гаргаснаар шинэ авто замын барилгын ажлыг санхүүжүүлдэг. “А” үндэсний засгийн газар нь хууль тогтоомжоор олгосон өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлж, уг авто замын удирдах байгууллагын бонд гаргалтанд баталгаа өгдөг. Баталгаа гаргах үед тухайлан тодорхойлсон тал байгаагүй бөгөөд баталгааг уг хэрэглүүрийн эзэмшигчдийн ашиг тусын төлөө шууд бусаар гаргасан.

Дээрх хоёр нөхцлийн аль алины хувьд гэрээний бусад бүх шинжүүд хангагдана гэж үзвэл уг санхүүгийн баталгаа нь мөн чанарын хувьд гэрээ болох юм.

#### *Даатгалын гэрээ*

- МЗУ5. Улсын секторын эдийн засгийн нэгдмэл зарим байгууллагууд нь даатгалын гэрээг гаргадаг тийм байгууллагуудыг өөртөө агуулсан байж болох юм. Эдгээр байгууллагууд нь энэ Стандартын цар хүрээнд хамаарах боловч даатгалын гэрээ нь өөрөө энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй юм.
- МЗУ6. Энэ Стандартын зорилгын хувьд даатгалын гэрээ гэдэг нь тодорхой хугацааны дотор гарч тохиолдсон буюу илэрсэн үйл явдал болон нөхцөл байдал, үүн дотроо өвчлөлт, хөдөлмөрийн чадвар алдалт, эд хөрөнгийн эвдрэл, бусдад учруулсан хохирол, үйл ажиллагааны тасалдалт (өөрөөр хэлбэл, амьдралын аннуитигийн хувьд уг тэтгэвэр авагч амьд байх) зэргийн улмаас учрах гарзын тогтоосон эрсдлийг даатгагчид хүлээлгэдэг гэрээ юм. Даатгалын гэрээний талаархи нэмэлт заавар удирдамжийг даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний холбогдох стандартуудаас үзэж болно.
- МЗУ7. Зарим санхүүгийн хэрэглүүр нь даатгалын гэрээний хэлбэртэй байх боловч зах зээлийн эрсдэл, зээлийн эрсдэл, төлбөрийн чадварын эрсдэл гэх мэт санхүүгийн эрсдлийн шилжилтийг үндсэндээ агуулсан байдаг. Ийм хэрэглүүрийн жишээнд санхүүгийн баталгааны гэрээ, давхар даатгал, улсын секторын даатгагчдын болон бусад байгууллагуудын гаргасан, баталгаат хөрөнгө оруулалтын гэрээ хамаардаг. Зарим санхүүгийн баталгааны гэрээнд энэ Стандартыг мөрдөхийг байгууллагаас шаарддаг бөгөөд санхүүгийн эрсдлийн шилжүүлэлтийг агуулсан бусад даатгалын гэрээнд энэ Стандартыг бас мөрдөхийг зөвшөөрдөг.
- МЗУ8. Байгууллага нь санхүүгийн баталгааны гэрээг энэ параграфын дагуу даатгалын гэрээ гэж үзэх сонголт хийсэн бөгөөд МЗУ9-р параграфын шаардлагуудыг мөн даган мөрддөг байхаас бусад тохиолдолд санхүүгийн баталгааны гэрээг санхүүгийн хэрэглүүр гэж үздэг. Байгууллага нь дараах тохиолдолд ийм сонголт хийж болно:
- (a) Байгууллага нь даатгалын гэрээнд хамаарах нягтлан бодох бүртгэлийг өмнө нь хэрэглэж байсан бөгөөд санхүүгийн баталгааны гэрээг даатгалын гэрээ гэж үзэх тийм нягтлан бодох бүртгэлийн бодлогыг баримталж байсан бол энэхүү Стандартын дагуу ийм

гэрээг даатгалын гэрээ эсвэл санхүүгийн хэрэглүүр гэж үзсэн хэвээр байж болно.

- (б) Байгууллага нь даатгалын гэрээнд хамаарах нягтлан бодох бүртгэлийг өмнө нь хэрэглэдэггүй байсан бол уг байгууллага нь энэ Стандартыг мөрдсөн үеэс санхүүгийн баталгааны гэрээг даатгалын гэрээ эсвэл санхүүгийн хэрэглүүр гэж үзэх сонголт хийж болох юм.

Дээрх (а) ба (б) хоёр тохиолдлын аль алины хувьд сонголтыг гэрээ тус бүрээр хийх бөгөөд хийсэн сонголт нь эргэлт буцалтгүй байна.

МЗУ9. Байгууллага нь даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний холбогдох стандартын дагуу ийм гэрээг даатгалын гэрээ гэж үзэх сонголт хийснээс бусад тохиолдолд уг байгууллага нь санхүүгийн баталгааны гэрээг 3(в) параграфын дагуу санхүүгийн хэрэглүүр гэж үзнэ. Хэрэв холбогдох даатгалын өр төлбөр нь УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-ийн цар хүрээнд хамаарах бол тодорхойлогдох байсан тийм дансны үнээс багагүй дүнгээр уг даатгалын өр төлбөрийг хэмжихийг үндэсний нягтлан бодох бүртгэлийн стандартаар шаарддаг зөвхөн тийм тохиолдолд тус байгууллага нь тэрхүү үндэсний стандартыг ашигласнаар санхүүгийн баталгааны гэрээг даатгалын гэрээ гэж үзэхийг түүнд зөвшөөрдөг. Даатгалын өр төлбөрийн дансны үнийг тодорхойлохдоо байгууллага нь түүний даатгалын гэрээнээс үүсэх бүх мөнгөн гүйлгээ болон холбогдох мөнгөн гүйлгээний талаархи одоогийн тооцооллыг харгалзан үзнэ.

## Тодорхойлолт (9-12-р параграф)

### *Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр*

МЗУ10. Валют (мөнгө) нь арилжаа солилцооны хэрэгслийг төлөөлдөг тул санхүүгийн хөрөнгө болох ба иймээс бүх ажил гүйлгээг хэмжиж, санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөх суурь юм. Банк буюу түүнтэй адилтгах санхүүгийн байгууллагад хадгалуулсан мөнгө нь тухайн санхүүгийн байгууллагаас мөнгө авах эсвэл санхүүгийн өр төлбөрийн төлбөр болгон зээлдүүлэгчид өгөхийн тулд дансны үлдэгдлийнхээ хувьд чек бичих буюу адилтгах хэрэглүүрийг гаргах хадгалуулагчийн гэрээний эрхийг төлөөлдөг тул санхүүгийн хөрөнгө болно. Харин гаргаж эргэлтэнд оруулаагүй валют нь санхүүгийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангахгүй. Байгууллага нь гаргаагүй аливаа валютыг тайлагнахдаа УСНББОУС 12, *Бараа Материал*-ын 13-р параграфыг мөрдөнө. Гаргагчийн зүгээс хууль ёсны мөнгөн тэмдэгт байдлаар гаргасан валютыг энэ Стандартад авч үзэхгүй.

МЗУ11. Ирээдүйд мөнгө хүлээн авах гэрээний эрхийг төлөөлөх санхүүгийн хөрөнгө ба ирээдүйд мөнгө шилжүүлэн өгөх гэрээний үүргийг төлөөлөх харгалзах санхүүгийн өр төлбөрийн нийтлэг жишээ нь:

- (а) Дансны авлага ба өглөг;  
(б) Авлагын бичиг ба өрийн бичиг;

- (в) Зээлийн авлага ба зээлийн өглөг; ба
- (г) Бондын авлага ба бондын өглөг.

Тохиолдол тус бүрд нэг талын мөнгө хүлээн авах гэрээний эрх (эсвэл төлөх үүрэг) нь нөгөө талын харгалзах мөнгө төлөх үүрэг (эсвэл хүлээн авах эрх)-тэй уялдаж байдаг.

МЗУ12. Санхүүгийн хэрэглүүрийн нөгөө нэг төрөл бол хүлээн авах буюу өгөх эдийн засгийн үр өгөөж нь мөнгөнөөс бусад санхүүгийн хөрөнгө байх хэрэглүүр юм. Жишээлбэл; Засгийн газрын бондын өрийн бичиг нь мөнгө биш, харин засгийн газрын бондыг хүлээн авах гэрээний эрхийг эзэмшигчдээ олгодог ба засгийн газрын бондыг өгөх гэрээний үүргийг гаргагчид хүлээлгэдэг. Бонд нь түүнийг гаргасан уг засгийн газрын мөнгө төлөх үүргийг илэрхийлэх тул санхүүгийн хөрөнгө юм. Иймээс уг өрийн бичиг нь түүнийг эзэмшигчийн хувьд санхүүгийн хөрөнгө, харин гаргагчийн хувьд санхүүгийн өр төлбөр болно.

МЗУ13. “Хугацаагүй” өрийн хэрэглүүр (“хугацаагүй” бонд, өрийн гэрээ, капиталын өрийн бичиг гэх мэт) нь ихэвчлэн ирээдүйн тодорхой бус хугацааны туршид тогтоосон өдрүүдээр хүүг тооцож авах гэрээний эрхийг эзэмшигчдээ олгодог боловч үндсэн дүнг буцаан авах эрхгүй эсвэл ирээдүйн маш тодорхойгүй буюу маш урт хугацаанд үндсэн төлбөрийг буцаан авах эрхтэй байдаг. Жишээлбэл; байгууллага нь 1,000ТН-ийн үндсэн дүн буюу нэрлэсэн үнээс 8 хувиар тооцох тогтоосон хүүг тодорхой бус хугацаанд жил бүр төлөхийг шаардсан санхүүгийн хэрэглүүрийг гаргаж болох юм. Уг хэрэглүүрийг гаргах үед зах зээлийн хүүний түвшин нь 8 хувь байсан гэж үзвэл гаргагч нь түүнийг анх хүлээн зөвшөөрөх үедээ 1,000ТН-ийн бодит үнэ цэнэ (өнөөгийн үнэ цэнэ) бүхий ирээдүйн хүүний төлбөрүүдийг барагдуулах гэрээний үүрэгтэй болно. Тухайн хэрэглүүрийн эзэмшигч ба гаргагч нь тус бүр санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөртэй байна.

МЗУ14. Санхүүгийн хэрэглүүрийг хүлээн авах, өгөх эсвэл солилцох гэрээний эрх буюу гэрээний үүрэг нь өөрөө санхүүгийн хэрэглүүр юм. Харилцан сүлжилдсэн гэрээний эрх ба гэрээний үүрэг нь эцсийн эцэст мөнгө хүлээн авах буюу төлөх, эсвэл өмчийн хэрэглүүрийг худалдан авах буюу гаргахад хүргэж байвал санхүүгийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангана.

МЗУ15. Гэрээний эрхийг хэрэгжүүлэх чадвар боломж эсвэл гэрээний үүргийг биелүүлэх шаардлага нь маргаангүй тодорхой эсвэл ирээдүйн үйл явдал гарч тохиолдох эсэхээс хамаарах болзошгүй байж болно. Жишээлбэл; санхүүгийн баталгаа нь хэрэв зээлдэгч төлбөрөө төлөхгүй бол баталгаа гаргагчаас мөнгө авах зээлдүүлэгчийн гэрээний эрх ба тухайн зээлдүүлэгчид мөнгө төлөх уг баталгаа гаргагчийн харгалзах гэрээний үүрэг юм. Хэдийгээр өөрийн эрхийг хэрэгжүүлэх зээлдүүлэгчийн чадвар боломж ба өөрийн үүргийн дагуу төлбөрийг гүйцэтгэх баталгаа гаргагчийн шаардлагын аль аль нь тухайн зээлдэгч төлбөрөө төлөхгүй байх ирээдүйн үйлдлээс хамаарах болзошгүй шинжтэй боловч өнгөрсөн ажил гүйлгээ буюу үйл явдал (баталгаа гаргалт)-ын үр дүн учраас гэрээний эрх ба үүрэг

оршин байна. Хэдийгээр ийм хөрөнгө, өр төлбөрийг санхүүгийн тайланд байнга хүлээн зөвшөөрөөд байдаггүй боловч болзошгүй эрх ба үүрэг нь санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангана. Ийм зарим болзошгүй эрх ба үүрэг нь даатгалын гэрээ байж болох юм.

МЗУ16. УСНББОУС 13, Түрээс-т заасанчлан, санхүүгийн түрээс нь зээлийн гэрээний дагуу үндсэн дүн ба хүүг нийлүүлэн төлөхтэй бараг ижил тийм цуврал төлбөрүүдийг хүлээн авах түрээслүүлэгчийн эрх ба тийм төлбөрүүдийг төлөх түрээслэгчийн үүргийг ерөнхийдөө бий болгодог. Түрээслүүлэгч нь санхүүгийн түрээсээр өгсөн тухайн суурь хөрөнгийн дүнгээр бус харин уг санхүүгийн түрээсийн дагуу авах авлагын дүнгээр өөрийн хөрөнгө оруулалтыг тайлагнана. Харин нөгөө талаас, үйлчилгээний хөлстэй адилтгах төлбөрийн хариуд тухайн хөрөнгийг ирээдүйн тайлант үеүдэд түрээслүүлэгчид ашиглуулах үүрэг хүлээсэн бүрэн хэрэгжээгүй гэрээ гэж үйл ажиллагааны түрээсийг ерөнхийдөө авч үздэг. Энэ тохиолдолд түрээслүүлэгч нь уг гэрээний дагуу ирээдүйд авах аливаа дүнгүүдийг биш, харин тухайн түрээслэсэн хөрөнгийг тайлагнасан хэвээр байна. Иймээс (одоо авах болон төлөх ёстой тухайлсан төлбөрүүдийг харгалзан үзэхээс бусад тохиолдолд) санхүүгийн түрээсийг санхүүгийн хэрэглүүр гэж үзнэ, харин үйл ажиллагааны түрээсийг санхүүгийн хэрэглүүр гэж үзэхгүй.

МЗУ17. Биет хөрөнгө (бараа материал, үндсэн хөрөнгө гэх мэт), түрээслэсэн хөрөнгө, биет бус хөрөнгө (патент, худалдааны тэмдэг гэх мэт) нь санхүүгийн хөрөнгө биш юм. Ийм биет болон биет бус хөрөнгийг хянах нь мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийн орлого олох боломжийг бүрдүүлэх боловч мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг хүлээн авах одоогийн эрхийг үүсгэхгүй.

МЗУ18. Эдийн засгийн үр өгөөж нь мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг хүлээн авах эрх бус, харин бараа, үйлчилгээний хүлээн авалт байх тийм хөрөнгө (урьдчилж төлсөн зардал гэх мэт) нь санхүүгийн хөрөнгө биш юм. Үүнтэй адилаар, хойшлогдсон орлого, ихэнх баталгаат өглөг зэрэгтэй зүйлстэй холбоотой эдийн засгийн үр өгөөжийн гадагш шилжүүлэлт нь мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг төлөх гэрээний үүрэг бус, харин бараа, үйлчилгээний нийлүүлэлт байдаг учраас эдгээр нь санхүүгийн өр төлбөр биш юм.

МЗУ19. Улсын секторт хөрөнгө ба өр төлбөр нь гэрээний болон гэрээний бус хэлцлүүдийн аль алианаас үүсдэг. Гэрээний бус хэлцлүүдээс үүсэх хөрөнгө ба өр төлбөр нь санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангадаггүй.

МЗУ20. Энэ Стандартын зорилгын хувьд “гэрээ” мөн эсэхийг тодорхойлохдоо байгууллага нь уг хэлцлийн хуулийн хэлбэрээс илүү мөн чанарыг харгалзан үздэг. Энэ Стандарын зорилгын хувьд гэрээ эсэхийг (хэдийгээр улс орон бүрд өөр өөр байж болох боловч) ерөнхийдөө дараах зүйлсээр нотолдог:



- Гэрээ нь хэлцэл хийхэд бэлэн байгаа талуудыг хамарсан байх;
- Гэрээний нөхцөл нь гэрээний талуудад эрх ба үүргийг үүсгэдэг бөгөөд тэдгээр эрх, үүрэг нь тал тус бүрийн хувьд ижил тэнцүү гүйцэтгэл бий болгох албагүй юм. Жишээлбэл; хандивын санхүүжилтийн хэлцэл нь байгуулсан гэрээний нөхцлийн дагуу нөөцийг уг хүлээн авагчид шилжүүлэх тухайн хандивлагчийн үүргийг бий болгодог бөгөөд тэрхүү нөөцийг авах хүлээн авагчийн эрхийг тогтоодог. Хэдийгээр хүлээн авагч нь хариу болгон адил тэнцүү төлбөр төлөхгүй, өөрөөр хэлбэл уг хэлцэл нь талуудын хувьд адил тэнцүү гүйцэтгэл бий болгох үр дүнгүй боловч ийм төрлийн хэлцэл нь гэрээ байж болох юм; ба
- Үл гүйцэтгэлийг засварлах арга хэмжээг хуулийн дагуу хүчин төгөлдөр хэрэгжүүлэхгүй.

МЗУ21. Улсын секторт гэрээний болон гэрээний бус хэлцлүүд нь мөн чанарын хувьд арилжааны бус шинжтэй байж болно. Арилжааны бус орлогын ажил гүйлгээнээс бий болсон хөрөнгө, өр төлбөрийг УСНББОУС 23, *Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Татвар ба Шилжүүлэл)*-ийн дагуу тайлагнадаг. Арилжааны бус орлогын ажил гүйлгээ нь гэрээ мөн бол ийм ажил гүйлгээнээс үүсэх хөрөнгө, өр төлбөр нь санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр эсэхийг тухайн байгууллага нь энэ Стандартын 10-р параграф болон МЗУ10-МЗУ18-р параграфыг ашиглан үнэлнэ. Арилжааны бус ажил гүйлгээ нь өр төлбөр эсвэл өмчийн хэрэглүүр (ээдээс оруулсан хувь оролцоо) үүсгэх эсэхийг үнэлэхдээ байгууллага нь энэ Стандарт болон УСНББОУС 23-д заасан заавар удирдамжийг ашиглана.

МЗУ22. Арилжааны бус гэрээний орлогын ажил гүйлгээний нэг хэсэг болох нөөцийн орлогын гүйлгээ нь мөн чанарын хувьд өр төлбөр эсвэл өмчийн хэрэглүүр эсэхийг тодорхойлохдоо байгууллага нь энэ Стандартын ангиллын шаардлагуудыг тусгайлан харгалзан үзнэ.

МЗУ23. Хууль ёсны үүргийг дараах гэх мэт олон арга замаар тайлагнаж болно:

- Орлогын татвар төлөх үүргийг уг орлогын татварыг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартын дагуу тайлагнана;
- Нийгмийн халамж үзүүлэх үүргийг УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* ба УСНББОУС 19-ийн дагуу тайлагнана.
- Бусад хууль ёсны үүргийг УСНББОУС 19-ийн дагуу тайлагнана.

МЗУ24. УСНББОУС 19-д тодорхойлсончлон, гэрээний бус үүрэг нь мөн гэрээнээс үүсдэггүй бөгөөд иймээс санхүүгийн өр төлбөр биш юм.

#### *Өмчийн хэрэглүүр*

МЗУ25. Улсын секторын хувьд байгууллагууд нь өмчийн хэрэглүүрээс тухайлбал, хувьцаа болон нэгж тоо ширхэг бүхий капиталын бусад хэлбэрээс бүрдэх

хувь нийлүүлсэн капиталтай байх нь түгээмэл бус байдаг. Байгууллагууд нь өмчийн хэрэглүүр гаргах тохиолдолд тэдгээр хэрэглүүрийн өмчлөл ба ашиглалтыг хууль тогтоомжоор хязгаарлаж болох юм. Жишээлбэл; улсын секторын байгууллагын хувьцааг зөвхөн улсын секторын өөр байгууллага өмчилж болох бөгөөд иймээс ажил гүйлгээг барагдуулах төлбөр болгон түүнийг ашиглахгүй гэж хууль тогтоомжинд заасан байж болно.

МЗУ26. Улсын сектор дахь хувь нийлүүлсэн капиталыг талуудын хоорондох нөөцийн шилжүүлэлтээр бас нотолж болох юм. Нөөцийн шилжүүлэлтийн хариуд өмчийн хэрэглүүр гаргалт нь уг шилжүүлэлт эздийн хувь оролцооны тодорхойлолтыг хангахад чухал ач холбогдолгүй байдаг. Байгууллагын цэвэр хөрөнгө/өмч дэх хувь оролцоог бий болгох үр дүн бүхий нөөцийн шилжүүлэлт нь дараах зүйлсээр нотлогдож болох учраас нөөцийн бусад шилжүүлэлтээс тэдгээрийг ялган зааглаж өгдөг:

- Ажил гүйлгээний оролцогч талууд нь уг хувь нийлүүлэлт хийгдэхээс өмнө эсвэл хувь нийлүүлэлтийн өдрөөр тэрхүү нөөцийн шилжүүлэлтийг (буюу ийм шилжүүлэлтийн ангийг) тухайн байгууллагын цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсэг байдлаар тодорхойлох албан ёсны сонголт ангилал. Жишээлбэл; шинэ байгууллагыг байгуулах үед санхүүгийн газрын төсвийн алба нь уг байгууллагад олгож буй нөөцийн анхны шилжүүлэлтийг үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагыг хангах санхүүжилт бүрдүүлэлт биш, харин тухайн байгууллагын цэвэр хөрөнгө/өмч дэх хувь оролцооны бүрдүүлэлт гэж үзэж болох юм.
- Тухайн байгууллагын цэвэр хөрөнгө/өмч дэх борлуулж, шилжүүлж эсвэл эргэлтээс гаргаж болох одоогийн санхүүгийн хувь оролцоог тогтоох буюу нэмэгдүүлэх уг шилжүүлэлттэй холбоотой албан ёсны хэлцэл.

Нөөцийн шилжүүлэлтийг сонголт ангилал буюу албан ёсны хэлцлээр нотолж болох боловч байгууллага нь тэдгээрийн зөвхөн хуулийн хэлбэр төдийгүй мөн чанарт үндэслэн уг нөөцийн шилжүүлэлтийн шинж төрлийг үнэлнэ.

МЗУ27. Энэ Стандартын зорилгын хувьд дараах зүйлсийг илэрхийлэхийн тулд “өмчийн хэрэглүүр” нэр томъёог ашиглаж болно:

- Энгийн буюу давуу эрхтэй хувьцаа гэх мэт нэгж тоо ширхэг бүхий капиталын хэлбэр;
- Өөр байгууллагын цэвэр хөрөнгө дэх үлдэх хувь оролцоог нотлон илэрхийлэх нөөцийн шилжүүлэлт (сонгон ангилсан эсвэл ажил гүйлгээний оролцогч талуудын хооронд зөвшөөрөн тохиролцсон гэх мэт); ба/буюу
- Хуулийн хэлбэрийн хувьд өр боловч мөн чанарын хувьд уг байгууллагын цэвэр хөрөнгө дэх хувь оролцоог илэрхийлэх санхүүгийн өр төлбөр.

*Буцаах эрхтэй хэрэглүүр*

МЗУ28. Байгууллагын хувь нийлүүлсэн капитал нь хувьцаа буюу нэгж тоо ширхэг бүхий капиталын бусад хэлбэрээс бүрддэг тохиолдолд тэдгээр хэрэглүүр нь олон янзын хэлбэртэй байж болно. Жишээлбэл; буцаах эрхгүй энгийн хувьцаа, зарим нэг буцаах эрхтэй хэрэглүүр (15 ба 16-р параграфыг үзнэ үү), байгууллагыг зөвхөн татан буулгах үед цэвэр хөрөнгийг хувь тэнцүүлэн нөгөө талдаа өгөх үүргийг тухайн байгууллагад хүлээлгэдэг зарим хэрэглүүр (17 ба 18-р параграфыг үзнэ үү), зарим төрлийн давуу эрхтэй хувьцаа (МЗУ49 ба МЗУ50-р параграфыг үзнэ үү), тогтмол дүн бүхий мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийн хариуд тухайн гаргагч байгууллагын тогтмол тоо ширхэгтэй, буцаах эрхгүй энгийн хувьцааг захиалах буюу худалдан авахыг эзэмшигчид зөвшөөрдөг баталгаа, гаргасан дуудах опцион хамаарна. Тогтмол дүн бүхий мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийн хариуд тогтмол тоо ширхэгтэй өөрийн өмчийн хэрэглүүрийг гаргах эсвэл худалдан авах уг байгууллагын үүрэг нь түүний өмчийн хэрэглүүр юм (27-р параграфт зааснаас бусад тохиолдолд). Гэхдээ ийм гэрээ (15, 16-р параграф эсвэл 17, 18-р параграфын дагуу өмчийн хэрэглүүр гэж ангилсан гэрээнээс бусад) нь мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг төлөх тухайн байгууллагын үүргийг агуулдаг бол энэ нь эргэлтээс гаргах дүнгийн өнөөгийн үнэ цэнээр мөн өр төлбөр үүсэхэд хүргэж болох юм (МЗУ51(а) параграфыг үзнэ үү). Буцаах эрхгүй энгийн хувьцааны гаргагч нь өмчийг хуваарилалт олгох албан ёсны үйлдэл хийсэн ба ингэж хуваарилах хууль ёсны үүргийг хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн тохиолдолд өр төлбөрийг хариуцна. Ногдол ашгийг зарласны дараа эсвэл тухайн байгууллага татан буугдаж байгаа бөгөөд өр төлбөрийг барагдуулсны дараа үлдэх аливаа хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах болсон үед ийм тохиолдол үүсэж болох юм.

МЗУ29. Тогтмол дүн бүхий мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг өгсөний хариуд тогтмол тоо хэмжээтэй өөрийн өмчийн хэрэглүүрийг буцаан худалдан авах эрхийг уг байгууллагад олгодог түүний худалдан авсан дуудах опцион буюу эзэмшиж буй адилтгах бусад гэрээ нь тухайн байгууллагын санхүүгийн хөрөнгө биш юм (27-р параграфт зааснаас бусад тохиолдолд). Харин ийм гэрээний хувьд төлсөн аливаа төлбөрийг цэвэр хөрөнгө/өмчөөс хасна.

**Бусад бүх ангиудтай харьцуулахад тэргүүн бус ээлжийн эрхтэй хэрэглүүрийн анги (15(б), 17(б) параграф)**

МЗУ30. 15 ба 17-р параграфт заасан нэг шинж бол бусад бүх ангиудтай харьцуулахад тэргүүн бус ээлжийн эрхтэй хэрэглүүрийн ангид уг санхүүгийн хэрэглүүр хамаардаг байх явдал юм.

МЗУ31. Хэрэглүүр нь тэргүүн бус ээлжийн эрхтэй ангид хамаарах эсэхийг тодорхойлохдоо, байгууллага нь хэрэв уг хэрэглүүрийг ангилах өдрийн байдлаар тэрээр татан буугдах байсан гэж үзвэл татан буулгалтаар тухайн хэрэглүүрийн гаргах нэхэмжлэлийг үнэлж үздэг. Хэрэв холбогдох нөхцөл байдал өөрчлөгдвөл байгууллага нь уг ангиллыг дахин нягталж

үнэлнэ. Жишээлбэл; байгууллага нь өөр санхүүгийн хэрэглүүрийг гаргасан эсвэл өөр санхүүгийн хэрэглүүрийг эргэлтээс гаргасан тохиолдолд бусад бүх ангиудтай харьцуулахад тэргүүн бус ээлжийн эрхтэй хэрэглүүрийн ангид тухайн авч үзэж буй хэрэглүүр хамаарах эсэхэд энэ нь нөлөө үзүүлж болох юм.

МЗУ32. Байгууллагыг татан буулгах үед давуу эрхтэй байх хэрэглүүр нь уг байгууллагын цэвэр хөрөнгөөс хувь тэнцүүлэн авах эрхтэй хэрэглүүрээс өөр байдаг. Жишээлбэл; хэрэглүүр нь байгууллагыг татан буулгах үед түүний цэвэр хөрөнгөөс хувь тэнцүүлэн авахаас гадна тогтмол ногдол ашиг авах эрхийг өөрийн эзэмшигчдээ олгодог бол энэ нь татан буулгалтын үеийн давуу эрхтэй байна. Харин тэргүүн бус ээлжийн эрхтэй ангид хамаарах бөгөөд тухайн байгууллагын цэвэр хөрөнгөөс хувь тэнцүүлэн авах эрх бүхий бусад хэрэглүүрүүд нь татан буулгалтын үед тогтмол ногдол ашиг авах ийм эрхгүй байдаг.

МЗУ33. Хэрэв байгууллага нь зөвхөн нэг ангийн санхүүгийн хэрэглүүртэй бол түүнийг бусад бүх ангиудтай харьцуулахад тэргүүн бус ээлжийн эрхтэй байсан мэтээр авч үзнэ.

**Хэрэглүүрийн хүчин төгөлдөр хугацааны туршид уг хэрэглүүрт хамаарах хүлээгдэж буй нийт мөнгөн гүйлгээ (15(д) параграф)**

МЗУ34. Хэрэглүүрийн хүчин төгөлдөр хугацааны туршид уг хэрэглүүрт хамаарах хүлээгдэж буй нийт мөнгөн гүйлгээ нь тухайн байгууллагын ашиг алдагдал, хүлээн зөвшөөрсөн цэвэр хөрөнгийн өөрчлөлт эсвэл хүлээн зөвшөөрсөн ба хүлээн зөвшөөрөөгүй цэвэр хөрөнгийн бодит үнэ цэнэд уг хэрэглүүрийн хүчин төгөлдөр хугацааны туршид гарсан өөрчлөлтөнд ихэвчлэн үндэслэх ёстой. Ашиг, алдагдал ба хүлээн зөвшөөрсөн цэвэр хөрөнгийн өөрчлөлтийг холбогдох УСНББОУС-ын дагуу хэмжинэ.

**Хэрэглүүрийн эзэмшигч нь тухайн байгууллагын эзнээс өөр бусад этгээд байдлаар хийсэн ажил гүйлгээ (15 ба 17-р параграф)**

МЗУ35. Буцаах эрхтэй санхүүгийн хэрэглүүр эсвэл байгууллагыг зөвхөн татан буулгах үед түүний цэвэр хөрөнгөөс хувь тэнцүүлэн нөгөө талдаа өгөх үүргийг тухайн байгууллагад хүлээлгэдэг хэрэглүүрийн эзэмшигч нь уг байгууллагын эзнээс өөр бусад этгээдийн үүрэгтэйгээр түүнтэй ажил гүйлгээ хийж болох юм. Жишээлбэл; хэрэглүүрийн эзэмшигч нь тухайн байгууллагын ажилтан бас байж болно. Хэрэглүүрийг 15-р параграф эсвэл 17-р параграфын дагуу өмчийн хэрэглүүр гэж ангилах хэрэгтэй эсэхийг үнэлэх үед тухайн байгууллагын зөвхөн эзний хувьд уг хэрэглүүрийн эзэмшигчид хамааралтай байх, тэрхүү хэрэглүүрийн мөнгөн гүйлгээ, гэрээний нөхцөл, болзлыг харгалзан үздэг.

МЗУ36. Үүний жишээ нь бүрэн ба бүрэн бус хариуцлагатай гишүүд бүхий хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл юм. Бүрэн хариуцлагатай зарим гишүүд нь тухайн байгууллагад баталгаа гарган өгч, баталгаа гарган өгснийхөө хариуд урамшуулал авдаг байж болох юм. Энэ тохиолдолд

баталгаа ба холбогдох мөнгөн гүйлгээ нь тухайн байгууллагын эзний хувьд гүйцэтгэж буй үүрэгтэй биш, харин баталгаа гаргагчийн хувьд гүйцэтгэж буй үүрэгтэй холбоотойгоор уг хэрэглүүрийн эзэмшигчид хамаарна. Иймээс энэхүү баталгаа ба холбогдох мөнгөн гүйлгээ нь бүрэн бус хариуцлагатай гишүүдтэй харьцуулахад бүрэн хариуцлагатай гишүүд тэргүүн бус ээлжийн эрхтэй гэж үзэхэд хүргэхгүй бөгөөд хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн хэрэглүүр ба бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн хэрэглүүрийн гэрээний нөхцлүүд нь хоорондоо адил төстэй эсэхийг үнэлэхэд уг баталгаа болон холбогдох мөнгөн гүйлгээг харгалзан үзэхгүй.

МЗУ37. Өөр нэг жишээ нь тухайн тайлант болон өмнөх жилүүдэд үзүүлсэн үйлчилгээ буюу хийсэн бизнест үндэслэн ашиг, алдагдлыг тухайн хэрэглүүрийн эзэмшигчдэд хуваарилдаг ашиг, алдагдал хуваах хэлцэл юм. Ийм хэлцлүүд нь тухайн байгууллагын эзэн биш гэдэг утгаар гүйцэтгэх үүрэгтэй холбоотойгоор уг хэрэглүүрийн эзэмшигчтэй хийх ажил гүйлгээ болох бөгөөд 15-р параграф эсвэл 17-р параграфт заасан шинжүүдийг үнэлэх үедээ эдгээрийг харгалзан үзэхгүй. Харин тухайн ангийн бусад хэрэглүүрүүдтэй харьцуулахад тэдгээрийн нэрлэсэн үнэд үндэслэн ашиг, алдагдлыг уг хэрэглүүрийн эзэмшигчдэд хуваарилдаг ашиг, алдагдал хуваах хэлцэл нь эзний хувьд тэдний гүйцэтгэх үүрэгтэй холбоотойгоор хэрэглүүрийн эзэмшигчидтэй хийсэн ажил гүйлгээг илэрхийлэх бөгөөд 15-р параграф эсвэл 17-р параграфт заасан шинжүүдийг үнэлэх үедээ эдгээрийг харгалзан үзнэ.

МЗУ38. Хэрэглүүрийн эзэмшигч (эзэн биш гэдэг утгаар гүйцэтгэх үүрэг) ба гаргагч байгууллагын хооронд хийсэн ажил гүйлгээний мөнгөн гүйлгээ, гэрээний нөхцөл, болзол нь хэрэглүүр эзэмшдэггүй тал ба тухайн гаргагч байгууллагын хооронд хийгдэж болох адилтгах ажил гүйлгээний мөнгөн гүйлгээ, гэрээний нөхцөл, болзолтой ижил төсөөтэй байх ёстой.

**Хэрэглүүрийн эзэмшигчид олгох уг үлдэх өгөөжийг мэдэгдэхүйц хязгаарлах буюу засварлан тогтоох нийт мөнгөн гүйлгээ бүхий бусад санхүүгийн хэрэглүүргүй эсвэл гэрээгүй байх(16 ба 18-р параграф)**

МЗУ39. Өмчийн хэрэглүүрийг 15 буюу 17-р параграфт заасан шалгуурыг бусад байдлаар хангахгүй санхүүгийн хэрэглүүр гэж ангилах нөхцөл нь тухайн байгууллага дараах шинж бүхий бусад санхүүгийн хэрэглүүр буюу гэрээгүй байх явдал юм: (а) нийт мөнгөн гүйлгээ нь тухайн байгууллагын ашиг алдагдал, хүлээн зөвшөөрсөн цэвэр хөрөнгийн өөрчлөлт эсвэл хүлээн зөвшөөрсөн ба хүлээн зөвшөөрөөгүй цэвэр хөрөнгийн бодит үнэ цэнэд гарсан өөрчлөлтөнд ихэвчлэн үндэслэдэг байх, (б) үлдэх өгөөжийг мэдэгдэхүйц хязгаарлах буюу засварлан тогтоох үр нөлөөтэй. Холбоогүй талуудтай худалдаа арилжааны хэвийн нөхцлөөр хийсэн дараах хэрэглүүр нь 15 буюу 17-р параграфт заасан шалгуурыг бусад байдлаар хангахгүй хэрэглүүрүүдийг өмчийн хэрэглүүр гэж ангилахад саад учруулах магадлал багатай байдаг:

- (а) Тухайн байгууллагын тодорхой хөрөнгүүдэд ихэвчлэн үндэслэх нийт мөнгөн гүйлгээ бүхий хэрэглүүр.
- (б) Орлогын хувийн жинд үндэслэсэн нийт мөнгөн гүйлгээ бүхий хэрэглүүр.
- (в) Байгууллагад хөдөлмөрийн үйлчилгээ үзүүлдэг тухайн тодорхой ажилтнуудыг шагнаан урамшуулах гэрээ.
- (г) Үзүүлсэн үйлчилгээ буюу нийлүүлсэн барааны хувьд ашгийн маш бага хувиар төлбөр төлөх гэрээ.

*Үүсмэл санхүүгийн хэрэглүүр*

МЗУ40. Санхүүгийн хэрэглүүрт анхдагч хэрэглүүр (авлага, өглөг, өмчийн хэрэглүүр гэх мэт) ба үүсмэл санхүүгийн хэрэглүүр (санхүүгийн опцион, фьючерс, форвард, хүүний түвшний своп, валютын своп гэх мэт) багтана. Үүсмэл санхүүгийн хэрэглүүр нь санхүүгийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангадаг тул энэ Стандартын цар хүрээнд хамаарна.

МЗУ41. Үүсмэл санхүүгийн хэрэглүүр нь анхдагч суурь санхүүгийн хэрэглүүрт угийн агуулагдаж буй нэг буюу хэд хэдэн санхүүгийн эрсдлүүдийг тухайн хэрэглүүрийн талуудын хооронд шилжүүлэх үр нөлөө бүхий эрх ба үүргийг бий болгодог. Анх эхлэх үеэсээ л үүсмэл санхүүгийн хэрэглүүр нь санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг боломжит тааламжтай нөхцлөөр нөгөө талтай солилцох гэрээний эрхийг нэг талд олгодог, эсвэл санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг боломжит тааламжгүй нөхцлөөр нөгөө талтай солилцох гэрээний үүргийг нэг талд хүлээлгэдэг. Гэвч ерөнхийдөө<sup>2</sup> энэ нь гэрээ анх эхлэх үед анхдагч суурь санхүүгийн хэрэглүүрийг шилжүүлэх үр дүнгүй, мөн гэрээ дуусгавар болох үед ч ийм шилжүүлэлтийг заавал хийсэн байх албагүй юм. Зарим хэрэглүүр нь солилцоо хийх эрх ба үүргийн аль алиныг агуулсан байдаг. Солилцооны нөхцлийг үүсмэл хэрэглүүрийн хугацааны эхэнд тодорхойлдог тул санхүүгийн зах зээл дэх үнэ өөрчлөгдсөнөөр уг нөхцөл нь тааламжтай эсвэл тааламжгүй болдог.

МЗУ42. Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийг (өөрөөр хэлбэл, байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрээс бусад санхүүгийн хэрэглүүрийг) солилцох эрхийн буцаах буюу дуудах опцион нь тухайн гэрээний суурь үндэслэл болох санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлттэй холбоотой ирээдүйн боломжит эдийн засгийн үр өгөөжийг олж авах эрхийг өөрийн эзэмшигчдээ олгодог. Харин эсрэгээр, опцион гаргагч нь уг суурь санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлттэй холбоотой ирээдүйн боломжит эдийн засгийн үр өгөөжөөс татгалзах эсвэл боломжит эдийн засгийн үр өгөөж алдалтыг хүлээх зөвшөөрөх үүрэг хүлээдэг. Эзэмшигчийн гэрээний эрх ба гаргагчийн үүрэг

---

<sup>2</sup> Энэ нь бүх үүсмэл хэрэглүүрийн хувьд биш харин ихэнх үүсмэл хэрэглүүрийн хувьд үнэн байна. Жишээлбэл; зарим валют хоорондох хүүний түвшний свопын үндсэн дүнгүүдийг гэрээний эхэнд солилцдог (ба хугацаа дуусгавар болоход буцаан солилцдог).

нь санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг тус тус хангана. Опционы гэрээний суурь үндэслэл болох санхүүгийн хэрэглүүр нь бусад байгууллагын хувьцаа, хүүтэй хэрэглүүр гэх мэт аливаа санхүүгийн хөрөнгө байж болно. Опцион нь санхүүгийн хөрөнгийг шилжүүлэх бус, харин өрийн хэрэглүүр гаргахыг тухайн гаргагчаас шаардаж болох боловч хэрэв опционыг хэрэгжүүлвэл уг опционы суурь үндэслэл болох хэрэглүүр нь түүнийг эзэмшигчийн санхүүгийн хөрөнгө болох юм. Боломжит тааламжтай нөхцлөөр санхүүгийн хөрөнгийг солилцох опцион эзэмшигчийн эрх ба боломжит тааламжгүй нөхцлөөр санхүүгийн хөрөнгийг солилцох гаргагчийн үүрэг нь уг опционы хэрэгжүүлэлтээр солилцох тухайн суурь хөрөнгөөс ялган тодорхойлж болохоор байдаг. Эзэмшигчийн эрх ба гаргагчийн үүргийн шинж төрөлд тухайн опционыг хэрэгжүүлэх эсэх магадлал нөлөөлөхгүй.

МЗУ43. Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн өөр нэг жишээ нь форвард гэрээ юм. Үүнд: нэг тал (худалдан авагч) нь 1,000,000ТН-ийн нэрлэсэн үнэтэй, тогтмол хүүтэй Засгийн газрын бондын хариуд 1,000,000ТН-ийн мөнгө төлөхөөр амласан, харин нөгөө тал (борлуулагч) нь 1,000,000ТН-ийн мөнгөний хариуд 1,000,000ТН-ийн нэрлэсэн үнэтэй, тогтмол хүүтэй Засгийн газрын бондыг өгөхөөр амласан бөгөөд зургаан сарын дараа барагдуулах форвард гэрээ байна. Энэхүү зургаан сарын хугацаанд хоёр талын аль аль нь санхүүгийн хэрэглүүрүүдийг солилцох гэрээний эрх ба гэрээний үүрэгтэй байх юм. Хэрэв засгийн газрын бондын зах зээлийн үнэ нь 1,000,000ТН-ээс их болж өсвөл уг нөхцөл байдал нь худалдан авагчид тааламжтай, харин борлуулагчид тааламжгүй болно; хэрэв зах зээлийн үнэ нь 1,000,000ТН-ээс бага болж буурвал дээрхээс эсрэг үр нөлөөтэй болно. Худалдан авагч нь эзэмшиж буй дуудах опционы эрхтэй ижил гэрээний эрх (санхүүгийн хөрөнгө)-тэй ба гаргасан буцаах опционы үүрэгтэй ижил гэрээний үүрэг (санхүүгийн өр төлбөр)-тэй байна; борлуулагч нь эзэмшиж буй буцаах опционы эрхтэй ижил гэрээний эрх (санхүүгийн хөрөнгө)-тэй ба гаргасан дуудах опционы үүрэгтэй ижил гэрээний үүрэг (санхүүгийн өр төлбөр)-тэй байх юм. Опционтой адилаар, эдгээр гэрээний эрх ба үүрэг нь тухайн суурь санхүүгийн хэрэглүүрүүдээс (солилцох бонд ба мөнгөнөөс) тусдаа бөгөөд ялган тодорхойлж болох санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийг үүсгэх юм. Форвард гэрээний хоёр талын аль аль нь тохирсон хугацаанд гүйцэтгэх үүргийг хүлээдэг, харин опционы эзэмшигч нь түүнийг хэрэгжүүлэх сонголт хийсэн зөвхөн тийм тохиолдолд опционы гэрээний дагуу гүйцэтгэл хийгдэнэ.

МЗУ44. Хүүний түвшний болон валютын своп, хүүний түвшний дээд хэмжээ, хүүний түвшний баталгаа, хүүний түвшний доод хэмжээ, зээл олгох баталгаа, өрийн бичиг гаргах хэрэгсэл, зээлийн захидал зэрэг бусад олон төрлийн үүсмэл хэрэглүүр нь ирээдүйд солилцоо хийх эрх буюу үүргийг агуулсан байдаг. Хүүний түвшний свопын гэрээг форвард гэрээний нэг хувилбар гэж үздэг бөгөөд энд талууд нь нэг мөнгөн дүнг хөвөгч хүүний түвшинг лавлагаа болгосноор, нөгөө мөнгөн дүнг тогтмол хүүний түвшинг лавлагаа болгосноор тооцоолж, ирээдүйн хэд хэдэн цуврал мөнгөн солилцоо хийхийг зөвшөөрдөг. Фьючерс гэрээ нь форвард гэрээний өөр

нэг хувилбар боловч уг гэрээг стандарт хэлбэр загвартай болгож, бирж дээр арилждаг нь түүний үндсэн ялгаатай тал юм.

Санхүүгийн бус зүйлсийг худалдан авах буюу борлуулах гэрээ (4-6-р параграф)

МЗУ45. Санхүүгийн бус хөрөнгө эсвэл үйлчилгээг хүлээн авах нэг талын гэрээний эрх ба нөгөө талын харгалзах үүрэг нь санхүүгийн хөрөнгийг хүлээн авах, өгөх эсвэл солилцох аль нэг талын одоогийн эрх, үүргийг үүсгэдэггүй тул санхүүгийн бус зүйлсийг худалдан авах буюу борлуулах гэрээ нь санхүүгийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангахгүй юм. Жишээлбэл; санхүүгийн бус зүйлийг зөвхөн хүлээн авснаар эсвэл өгснөөр биелэлт хангагдах гэрээ (жишээлбэл; опцион, газрын тосны фьючерс буюу форвард гэрээ) нь санхүүгийн хэрэглүүр биш юм. Бараа бүтээгдэхүүний олон гэрээ нь ийм төрөлд хамаардаг. Зарим гэрээ нь хэлбэрийн хувьд стандартчлагдсан байх бөгөөд зохион байгуулалттай зах зээлд зарим үүсмэл санхүүгийн хэрэглүүртэй адил арилжаалагддаг. Жишээлбэл; бараа бүтээгдэхүүний фьючерс гэрээг бирж дээр гаргаж, гараас гарт олон удаа дамжиж болох тул түүнийг мөнгөөр шууд худалдан авах буюу борлуулж болох юм. Гэвч уг гэрээг худалдан авах ба борлуулах талууд нь үнэн хэрэгтээ тухайн суурь бараа бүтээгдэхүүнийг арилжиж байдаг. Бараа бүтээгдэхүүний гэрээг мөнгөөр худалдан авах буюу борлуулах чадвар боломж, худалдан авах буюу борлуулж болох хялбар дөхөм байдал, бараа бүтээгдэхүүнийг хүлээн авах буюу нийлүүлэх үүргийг мөнгөөр барагдуулахаар хэлцэл хийх боломжтой байдал зэрэг нь санхүүгийн хэрэглүүр үүсгэхүйц тийм байдлаар уг гэрээний үндсэн шинж чанарыг өөрчлөхгүй юм. Гэвч санхүүгийн бус зүйлсийг худалдан авах буюу борлуулах зарим гэрээг цэвэр дүнгээр барагдуулах буюу санхүүгийн хэрэглүүрээр солилцох, эсвэл уг гэрээнд хамаарах санхүүгийн бус зүйлийг мөнгөнд шууд хөрвүүлэх боломжтой бол тийм гэрээ нь санхүүгийн хэрэглүүрийн нэг адилаар энэхүү Стандартын цар хүрээнд хамаарна (4-р параграфыг үзнэ үү).

МЗУ46. Биет шинжтэй хөрөнгийг шилжүүлсэн өдрөөс хойш түүний аливаа харгалзах төлбөрийг хойшлуулаагүй л бол биет шинжтэй хөрөнгийг хүлээн авах буюу нийлүүлэх гэрээ нь нэг талын санхүүгийн хөрөнгө ба нөгөө талын санхүүгийн өр төлбөр үүсэхэд хүргэхгүй. Барааг худалдааны зээлээр худалдан авах буюу борлуулах үед төлбөрийг хойшлуулах ийм тохиолдол үүсдэг.

МЗУ47. Зарим гэрээ нь бараа бүтээгдэхүүнтэй холбоотой боловч тухайн бараа бүтээгдэхүүнийг биетээр хүлээн авах буюу нийлүүлснээр төлбөрийг барагдуулах заалтыг өөртөө агуулаагүй байдаг. Ийм гэрээ нь тогтмол дүн бүхий төлбөрөөр биш, харин гэрээнд дурдсан томъёоны дагуу тодорхойлогдох мөнгөн дүнгээр төлбөрийг барагдуулахаар тусгайлан заасан байдаг. Жишээлбэл; бондын дуусгавар болох өдрөөр давамгайлж буй газрын тосны зах зээлийн үнийг газрын тосны тогтмол тоо хэмжээгээр үржүүлсэнээр бондын үндсэн дүнг тооцоолдог байж болно. Бараа бүтээгдэхүүний үнийг лавлагаа болгосноор үндсэн дүнг индексжүүлэн



тооцох боловч төлбөрийг зөвхөн мөнгөөр барагдуулна. Ийм гэрээ нь санхүүгийн хэрэглүүр болно.

МЗУ48. Санхүүгийн хэрэглүүрийн тодорхойлолт нь санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрөөс гадна санхүүгийн бус хөрөнгө эсвэл санхүүгийн бус өр төлбөр үүсэхэд хүргэх гэрээг мөн өөртөө агуулдаг. Ийм санхүүгийн хэрэглүүр нь санхүүгийн хөрөнгийг санхүүгийн бус хөрөнгөөр солилцох опционыг аль нэг талд ямагт олгодог. Жишээлбэл; газрын тостой холбоотой бонд нь үндсэн дүнг тодорхой тоо хэмжээний газрын тосоор солилцох опционы хамтаар тогтмол дүнтэй үечилсэн хүүний төлбөрүүд болон дуусгавар болох өдөр тогтмол дүн бүхий мөнгө авах эрхийг эзэмшигчдээ олгож болох юм. Ийм опционыг хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэл нь тухайн бондын гэрээнд агуулагдах мөнгө ба газрын тосны хоорондох солилцооны харьцаанд (солилцооны үнэд) харгалзах тухайн газрын тосны бодит үнэ цэнээс хамааран нэг цаг хугацаанаас нөгөө цаг хугацаанд өөрчлөгдөж байдаг. Опционыг хэрэгжүүлэх талаархи бонд эзэмшигчийн төлөвлөгөө нь тухайн бүрэлдэхүүн хөрөнгүүдийн мөн чанарт нөлөөлөхгүй. Эзэмшигчийн санхүүгийн хөрөнгө ба гаргагчийн санхүүгийн өр төлбөр нь бусад төрлийн хөрөнгө, өр төлбөр бас үүсэх эсэхээс үл хамааран уг бондыг санхүүгийн хэрэглүүр болоход хүргэнэ.

## **Толилуулга**

*Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмч (13-32-р параграф)*

### **Мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг өгөх гэрээний үүрэггүй байх (21-24-р параграф)**

МЗУ49. Давуу эрхтэй хувьцааг янз бүрийн эрхтэйгээр гаргаж болно. Давуу эрхтэй хувьцаа нь санхүүгийн өр төлбөр эсвэл өмчийн хэрэглүүр эсэхийг тодорхойлохдоо, гаргагч нь уг давуу эрхтэй хувьцаанд санхүүгийн өр төлбөрийн үндсэн шинж чанарууд байгаа эсэхийг тогтоох үүднээс тэрхүү хувьцаанд хамаарах тусгай эрхүүдийг үнэлж үздэг. Жишээлбэл; тодорхой заасан хугацаанд эсвэл эзэмшигчийн сонголтоор эргэлтээс гаргах боломжтой давуу эрхтэй хувьцаа нь санхүүгийн өр төлбөр юм. Яагаад гэвэл, гаргагч нь уг хувьцааны эзэмшигчид санхүүгийн хөрөнгө шилжүүлэх үүрэг хүлээж байна. Мөнгө сангийн хүрэлцээгүй байдал, хууль эрх зүйн хязгаарлалт, хангалттай бус ашиг, хүрэлцээгүй нөөц зэргийн улмаас гэрээгээр шаардсан хугацаанд давуу эрхтэй хувьцаагаа эргэлтээс гаргах үүргээ тухайн гаргагч биелүүлэх чадваргүй байдал нь түүнийг уг үүргээс чөлөөлөхгүй. Харин мөнгөөр төлж, хувьцааг эргэлтээс гаргах гаргагчийн сонголт нь санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангахгүй. Яагаад гэвэл, уг гаргагч нь хувьцаа эзэмшигчдэд санхүүгийн хөрөнгийг шилжүүлэх одоогийн үүрэггүй байна. Өөрөөр хэлбэл, энэ тохиолдолд хувьцааг эргэлтээс гаргах эсэх нь зөвхөн гаргагчийн хүсэл эрмэлзлээс хамаарч байна. Харин хувьцааг гаргагч нь тухайн хувьцааг эргэлтээс гаргах өөрийн төлөвлөгөөг хувьцаа эзэмшигчдэд ихэвчлэн албан ёсоор мэдэгдэж, энэхүү сонголтыг хэрэгжүүлсэн үед үүрэг үүсэж болох юм.

МЗУ50. Давуу эрхтэй хувьцааг эргэлтээс үл гаргах бол түүнд хамаарах бусад эрхүүдээр зохих ангиллыг тодорхойлно. Ийм ангилал нь гэрээ хэлцлийн мөн чанар, санхүүгийн өр төлбөр ба өмчийн хэрэглүүрийн тодорхойлолтын үнэлгээнд үндэслэдэг. Хуримтлалтай эсвэл хуримтлалгүй эсэхээс үл хамааран давуу эрхтэй хувьцаа эзэмшигчдэд олгох хуваарилалт нь тухайн гаргагчийн санал хүслээс хамаардаг тохиолдолд уг хувьцаа нь өмчийн хэрэглүүр болно. Давуу эрхтэй хувьцааг өмчийн хэрэглүүр эсвэл санхүүгийн өр төлбөр гэж ангилах ангилалд тухайлбал, дараах зүйлс нөлөөлөхгүй. Үүнд:

- (a) Хуваарилалт хийж байсан түүх;
- (б) Ирээдүйд хуваарилалт хийх төлөвлөгөө;
- (в) Хэрэв хуваарилалт хийхгүй бол тухайн гаргагчийн энгийн хувьцааны үнэд үзүүлэх боломжит сөрөг нөлөө (хэрэв давуу эрхтэй хувьцаанд ногдол ашиг хуваарилаагүй бол энгийн хувьцаанд ногдол ашиг төлөхийг хязгаарласны улмаас);
- (г) Гаргагчийн нөөцийн дүн;
- (д) Тайлант үеийн ашиг, алдагдлын талаархи гаргагчийн хүлээлт; эсвэл
- (е) Тухайн тайлант үеийн ашиг, алдагдлын дүндээ уг гаргагч нөлөөлөх боломжит байдал эсвэл ийм боломжгүй байдал.

**Байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрээр барагдуулалт (25-29-р параграф)**

МЗУ51. МЗУ25-р параграфт тэмдэглэсэнчлэн, улсын секторын хувьд байгууллагууд нь хувьцаа буюу нэгж тоо ширхэг бүхий капиталын бусад хэлбэрээс бүрдэх өмчийн хэрэглүүрийг гаргах нь түгээмэл бус байдаг; ийм хэрэглүүртэй байх тохиолдолд тэдгээр хэрэглүүрийн өмчлөл ба ашиглалтыг хууль тогтоомжоор ихэвчлэн хязгаарладаг. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн капиталын бүтцээс ерөнхийдөө өөр байх улсын секторын байгууллагуудын капиталын бүтэц ба улсын секторын байгууллагуудын үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг эрх зүйн орчны улмаас тухайн байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрээр барагдуулах ажил гүйлгээ нь улсын секторын хувьд хувийн хэвшлийнхтэй адил байнга гарч тохиолдоод байдаггүй. Гэвч ийм ажил гүйлгээ гарч тохиолдсон бол янз бүрийн гэрээг тухайн байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрээр хэрхэн ангилахыг үлгэрчлэн харуулахад дараах жишээ туслалцаа үзүүлж болох юм:

- (a) Ирээдүйд ямар нэг төлбөр хийхгүй боловч тогтмол тоо ширхэгтэй өөрийн өмчийн хувьцааг авах буюу өгснөөр, эсвэл тогтмол тоо ширхэгтэй өөрийн өмчийн хувьцааг тогтмол дүн бүхий мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгөөр солилцсоноор тухайн байгууллагын барагдуулах гэрээ нь (27-р параграфт зааснаас бусад тохиолдолд) өмчийн хэрэглүүр болно. Тийм учраас ийм гэрээний дагуу хүлээн авсан буюу төлсөн аливаа төлбөрийг цэвэр хөрөнгө/өмчид шууд нэмэх буюу цэвэр хөрөнгө/өмчөөс шууд хасна. Үүний нэг жишээ нь;

байгууллагын тогтмол тоо ширхэгтэй хувьцааг тогтмол дүн бүхий мөнгөөр худалдан авах эрхийг нөгөө талдаа олгодог, гаргасан хувьцааны опцион юм. Харин уг гэрээ нь төвлөсөн буюу тодорхойлж болох өдөр эсвэл шаардсан үед нь, өөрийн өмчийн хувьцааг мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгөөр худалдан авахыг (эргэлтээс гаргахыг) байгууллагаас шаарддаг бол тухайн байгууллага нь уг эргэлтээс гаргах дүнгийн өнөөгийн үнэ цэнээр санхүүгийн өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрнө (15 ба 16-р параграф эсвэл 17 ба 18-р параграфуудад заасан бүх шинжүүдтэй бөгөөд нөхцлүүдийг хангадаг хэрэглүүрээс бусад тохиолдолд). Өөрийн тогтмол тоо ширхэгтэй өмчийн хувьцааг тогтмол дүн бүхий мөнгөөр буцаан худалдан авахаар форвард гэрээний дагуу тухайн байгууллагын хүлээсэн үүрэг нь үүний нэг жишээ болно.

- (б) Тухайн байгууллага буцаан худалдан авахаар үүрэг хүлээсэн хувьцааны тоо нь тогтмол бус эсвэл уг үүрэг нь нөгөө тал эргэлтээс гаргах эрхээ хэрэгжүүлэх эсэхээс нөхцөл хамааралтай байлаа ч гэсэн өөрийн өмчийн хувьцааг мөнгөөр худалдан авах байгууллагын үүрэг нь тэрхүү эргэлтээс гаргах дүнгийн өнөөгийн үнэ цэнээр санхүүгийн өр төлбөр хүлээн зөвшөөрөхөд хүргэнэ (15 ба 16-р параграф эсвэл 17 ба 18-р параграфт зааснаас бусад тохиолдолд). Нөхцөлт үүргийн нэг жишээ нь; хэрэв нөгөө тал нь уг опционыг хэрэгжүүлвэл өөрийн өмчийн хувьцааг мөнгөөр буцаан худалдан авахыг тухайн байгууллагаас шаарддаг гаргасан опцион юм.
- (в) Хэдийгээр хүлээн авах эсвэл өгөх мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийн дүн нь тухайн байгууллагын өөрийн өмчийн зах зээлийн үнийн өөрчлөлтөнд үндэслэдэг байлаа ч гэсэн мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгөөр барагдуулах гэрээ нь санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөр юм (15 ба 16-р параграф эсвэл 17 ба 18-р параграфт зааснаас бусад тохиолдолд). Үүний нэг жишээ бол цэвэр дүнгээр нь мөнгөөр барагдуулах хувьцааны опцион юм.
- (г) Тогтмол дүнтэй эсвэл суурь хувьсагч (жишээ нь; бараа бүтээгдэхүүний үнэ)-ийн өөрчлөлтөөс хамаарах дүнтэй тэнцүү байх үнэ цэнэ бүхий тухайн байгууллагын өөрийн өмчийн хувьсах тоо ширхэгтэй хувьцаагаар барагдуулах гэрээ нь санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр юм. Жишээлбэл; газрын тос худалдан авахын тулд гаргасан опцион. Опционыг хэрэгжүүлсэн үед тухайн байгууллага нь уг опционы гэрээний үнэ цэнэтэй тэнцүү байх тийм тоо ширхэгтэй өөрийн өмчийн хэрэглүүрийг өгөх замаар түүнийг цэвэр дүнгээр нь барагдуулна. Хэдийгээр суурь хувьсагч нь газрын тос биш, харин тухайн байгууллагын өөрийн хувьцааны үнэ боловч ийм гэрээ нь санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр болно. Үүнтэй адилаар, тухайн байгууллагын тогтмол тоо ширхэгтэй өөрийн өмчийн хувьцаагаар барагдуулах боловч уг барагдуулалтын үнэ цэнэ нь тогтмол дүнтэй эсвэл суурь хувьсагчийн өөрчлөлтөнд үндэслэсэн дүнтэй тэнцүү байхын тулд тэдгээр хувьцаанд хавсаргасан эрх нь хувьсан өөрчлөгдөж байдаг гэрээ нь санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр юм.

**Төлбөр барагдуулалтын болзошгүй нөхцлүүд (30-р параграф)**

МЗУ52. Мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгөөр төлбөр барагдуулахыг (хэрэв санхүүгийн өр төлбөр байсан бол төлөх байсан тийм арга замаар барагдуулахыг) шаардаж болох уг төлбөр барагдуулалтын зарим болзошгүй нөхцөл нь бодитой бус бол тухайн төлбөр барагдуулалтын нөхцөл нь санхүүгийн хэрэглүүрийн ангилалд нөлөөлөхгүй байхаар 30-р параграфт заасан байдаг. Иймээс туйлын ховор, ихээхэн хэвийн бус бөгөөд гарч тохиолдох магадлал маш багатай тийм үйл явдал зөвхөн гарч тохиолдсон үед тухайн байгууллагын өөрийн өмчийн хувьсах тоо ширхэгтэй хувьцаагаар эсвэл мөнгөөр барагдуулахыг шаарддаг гэрээ нь өмчийн хэрэглүүр болно. Үүнтэй адилаар, байгууллагын тогтмол тоо ширхэгтэй өөрийн хувьцаагаар төлбөр барагдуулахыг тухайн байгууллагын хяналтаас гадуурх нөхцөл байдалд гэрээ хэлцлийн дагуу хориглон хязгаарлаж болох боловч тийм нөхцөл байдал гарч тохиолдох бодит боломжгүй бол өмчийн хэрэглүүр гэж ангилах нь зохистой юм.

**Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн арга хандлага**

МЗУ53. Байгууллага нь хяналтын бус хувь оролцоог, өөрөөр хэлбэл, өөрийн хяналтанд буй байгууллагуудын цэвэр хөрөнгө/өмч ба орлого дахь бусад талуудын хувь оролцоог УСНББОУС 1 ба УСНББОУС 35-ын дагуу нэгтгэсэн санхүүгийн тайланд толилуулна. Санхүүгийн хэрэглүүр (буюу түүний бүрэлдэхүүн хэсэг)-ийг нэгтгэсэн санхүүгийн тайланд ангилах тохиолдолд бүхэлдээ уг эдийн засгийн нэгдмэл байгууллага нь тухайн хэрэглүүрийн хувьд мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг өгөх эсвэл өр төлбөрөөр ангилахад хүргэх тийм байдлаар түүнийг барагдуулах үүрэгтэй эсэхийг тодорхойлох үүднээс эдийн засгийн нэгдмэл байгууллагын гишүүд ба хэрэглүүрийн эзэмшигчдийн хоорондоо харилцан тохиролцсон бүх нөхцөл, болзлуудыг тухайн байгууллага нь харгалзан үзнэ. Хяналтанд буй байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийг гаргасан ба хяналт тавигч байгууллага эсвэл тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх бусад байгууллага нь нэмэлт нөхцлүүдийг (жишээлбэл; баталгаа) уг хэрэглүүрийн эзэмшигчидтэй шууд тохиролцсон тохиолдолд тэрхүү эдийн засгийн нэгдмэл байгууллага нь ногдол ашиг олголт эсвэл хэрэглүүрийн эргэлтээс гаргалтаас зайлсхийх боломжгүй байж болох юм. Хяналтанд буй байгууллага нь эдгээр нэмэлт нөхцлүүдийг харгалзан үзэхгүйгээр тухайн хэрэглүүрийг өөрийн тусдаа санхүүгийн тайландаа зохих ёсоор ангилж болох боловч бүхэлдээ уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын хийсэн гэрээ болон ажил гүйлгээг тухайн нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгасан эсэхийг магадлахын тулд тэрхүү эдийн засгийн нэгдмэл байгууллагын гишүүд ба хэрэглүүрийн эзэмшигчдийн хоорондох бусад хэлцлүүдийн үр нөлөөг харгалзан үзнэ. Ийм үүрэг буюу барагдуулалтын нөхцөл байгаа (эсвэл түүний аль нэг бүрэлдэхүүн хэсэг нь ийм үүрэгт хамаарах) тохиолдолд уг хэрэглүүрийг нэгтгэсэн санхүүгийн тайланд санхүүгийн өр төлбөр гэж ангилна.

МЗУ54. Байгууллагад гэрээний үүрэг хүлээлгэдэг зарим төрлийн хэрэглүүрийг 15 ба 16-р параграф эсвэл 17 ба 18-р параграфын дагуу өмчийн хэрэглүүр гэж ангилна. Эдгээр параграфуудын дагуу хийх ангилал нь хэрэглүүрийн

ангиллын хувьд мөрдөхөөр энэ Стандартад заасан зарчмуудын гажих тохиолдол бөгөөд бусад хэрэглүүрт адилтган мөрдөж болохгүй юм. Энэхүү гажих тохиолдол нь хяналтын бус хувь оролцоог нэгтгэсэн санхүүгийн тайланд ангилахад хамаарахгүй. Иймээс 15 ба 16-р параграфын дагуу эсвэл 17 ба 18-р параграфын дагуу тусдаа буюу бие даасан санхүүгийн тайланд хяналтын бус хувь оролцоо буюу өмчийн хэрэглүүр гэж ангилсан хэрэглүүрийг тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд өр төлбөр гэж ангилна.

*Нийлмэл санхүүгийн хэрэглүүр (33-37-р параграф)*

МЗУ55. Үүсмэл бус нийлмэл санхүүгийн хэрэглүүрийн гаргагч л 33-р параграфыг мөрдөнө. 33-р параграф нь эзэмшигчийн зүгээс авч үзсэн нийлмэл санхүүгийн хэрэглүүрт хамаарахгүй. Өр ба өмчийн хэрэглүүрийн аль алины шинжийг агуулсан нийлмэл санхүүгийн хэрэглүүрийн эзэмшигчийн зүгээс авч үзсэн, дагалдах үүсмэл хэрэглүүрийн ялган тусгаарлалтыг УСНББОУС 29-д авч үзсэн.

МЗУ56. Улсын секторын байгууллагуудын капиталын бүтцээс хамааран нийлмэл санхүүгийн хэрэглүүр нь улсын секторт нийтлэг бус байдаг. Гэвч нийлмэл санхүүгийн хэрэглүүрийг түүний бүрэлдэхүүн хэсгүүдэд хэрхэн задлан шинжлэхийг дараах хэлэлцүүлэгт үлгэрчлэн харуулав. Нийлмэл санхүүгийн хэрэглүүрийн нийтлэг хэлбэр нь гаргагчийн энгийн хувьцаанд хөрвөх бонд гэх мэт дагалдах хөрвөх опционтой боловч дагалдах аливаа бусад үүсмэл шинжүүдгүй өрийн хэрэглүүр юм. Ийм санхүүгийн хэрэглүүрийн гаргагч нь өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсэг ба цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгийг санхүүгийн байдлын тайландаа дараах байдлаар тус тусад нь толилуулахыг 33-р параграфтаар шаардсан байдаг:

- (a) Хүү ба үндсэн дүнгийн хуваарьт төлбөрүүдийг төлөх тухайн гаргагчийн үүрэг нь уг хэрэглүүрийг хөрвүүлэх хүртэл оршин байх санхүүгийн өр төлбөр юм. Анх хүлээн зөвшөөрөх үед уг өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсгийн бодит үнэ цэнэ нь тухайн гэрээний дагуу тодорхойлсон ирээдүйн мөнгөн гүйлгээний урсгалуудыг дискаунтчилсан өнөөгийн үнэ цэнэ байдаг. Зээлийн адилтгах статустай бөгөөд ижил нөхцлийн дагуу үндсэндээ ижил мөнгөн гүйлгээг бий болгох боловч хөрвөх опционгүй тийм хэрэглүүрүүдийн зах зээлд тухайн хугацаанд хэрэглэгдэж буй хүүний түвшнээр дээрх мөнгөн урсгалуудыг дискаунтчилдаг.
- (б) Өмчийн хэрэглүүр нь өр төлбөрийг тухайн гаргагчийн цэвэр хөрөнгө/өмчид хөрвүүлэх дагалдах опцион юм. Уг опционы бодит үнэ цэнэ нь түүний цаг хугацааны үнэ цэнэ ба хэрэв байгаа бол түүний дотоод үнэ цэнээс бүрдэнэ. Ийм опцион нь мөнгөн алдагдалтай байлаа ч гэсэн анх хүлээн зөвшөөрөх үед үнэ цэнэтэй байдаг.

МЗУ57. Хөрвөх хэрэглүүрийн дуусгавар хугацаа болж, түүнийг хөрвүүлэх үед тухайн байгууллага нь өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсгийг үл хүлээн

зөвшөөрч, түүнийг цэвэр хөрөнгө/өмч гэж хүлээн зөвшөөрнө. Анхнаасаа цэвэр хөрөнгө/өмчөөр ангилагдсан бүрэлдэхүүн хэсэг нь (хэдийгээр цэвэр хөрөнгө/өмчийн доторх нэг мөрийн зүйлээс нөгөө мөрийн зүйлд шилжүүлж болох боловч) цэвэр хөрөнгө/өмч хэвээрээ үлдэнэ. Дуусгавар болох үед хийгдсэн хөрвүүлэлтээр олз, гарз үүсэхгүй.

МЗУ58. Байгууллага нь хөрвүүлэлтийн анхны давуу эрхийг өөрчлөхгүйгээр эргэлтээс эрт гаргах буюу буцаан худалдан авах замаар тухайн дуусгавар болох хугацаанаас өмнө хөрвөх хэрэглүүрийг барагдуулсан тохиолдолд уг байгууллага нь энэхүү буцаан худалдан авалт буюу эргэлтээс гаргалттай холбоотойгоор төлсөн төлбөр болон аливаа ажил гүйлгээний зардлыг тэрхүү ажил гүйлгээний өдрөөр хэрэглүүрийн өр төлбөрийн болон өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваарилна. Төлсөн төлбөр болон ажил гүйлгээний зардлыг уг тусдаа бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваарилахдаа ашиглах арга нь тухайн хөрвөх хэрэглүүрийг гаргаснаар байгууллагын хүлээн авсан орлогыг 33-37-р параграфын дагуу тэдгээр тусдаа бүрэлдэхүүн хэсгүүдэд анх хуваарилахад ашигласан аргатай нийцсэн байвал зохино.

МЗУ59. Төлбөрийн хуваарилалтыг хийснээр үүссэн аливаа олз, гарзыг тухайн холбогдох бүрэлдэхүүн хэсэгт хамаарах нягтлан бодох бүртгэлийн зарчмуудын дагуу дараах байдлаар бүртгэнэ:

- (а) Өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсэгтэй холбоотой олз, гарзын дүнг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө; ба
- (б) Цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсэгтэй холбоотой төлбөрийн дүнг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө.

МЗУ60. Байгууллага нь эрт хөрвүүлэлтийг дэмжихийн тулд тухайлбал, илүү тааламжтай хөрвөх харьцааг санал болгох эсвэл тусгайлан заасан өдрөөс өмнө хөрвүүлвэл бусад нэмэлт төлбөр төлөх гэх мэтээр уг хөрвөх хэрэглүүрийн нөхцөлд өөрчлөлт оруулж болох юм. Тухайн өөрчилсөн нөхцлийн дагуу хэрэглүүрийг хөрвүүлснээр уг эзэмшигчийн хүлээн авах төлбөрийн бодит үнэ цэнэ ба анхны нөхцлийн дагуу эзэмшигч хүлээн авах байсан төлбөрийн бодит үнэ цэнийн хоорондох зөрүүг тэрхүү нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулсан өдрөөр ашиг, алдагдалд гарз гэж хүлээн зөвшөөрнө.

*Халаасны хувьцаа (38 ба 39-р параграф)*

МЗУ61. Байгууллага өөрийн өмчийн хэрэглүүрийг буцаан худалдан авсан шалтгаанаас үл хамааран түүнийг санхүүгийн хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхгүй. 38-р параграфт шаардсаны дагуу, өөрийн өмчийн хэрэглүүрийг буцаан худалдан авч буй байгууллага нь уг өмчийн хэрэглүүрийн дүнгээр цэвэр хөрөнгө/өмчөө бууруулна. Харин байгууллага нь өөрийн өмчийг бусдын нэрийн өмнөөс эзэмшиж байгаа, жишээлбэл, санхүүгийн байгууллага нь үйлчлүүлэгчийнхээ нэрийн өмнөөс өөрийн өмчийн хэрэглүүрийг эзэмшиж байгаа тохиолдолд агентын харилцаа үүсэх тул ийм эзэмшилтийг тухайн байгууллагын санхүүгийн байдлын тайланд тусгахгүй.

*Хүү, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт, гарз ба олз (40-46-р параграф)*

МЗУ62. Нийлмэл санхүүгийн хэрэглүүрт 40-р параграфыг хэрхэн мөрдөхийг энэхүү жишээнд тайлбарласан. Хуримтлалгүй давуу эрхтэй хувьцааг таван жилийн дараа мөнгөөр заавал эргэлтээс гаргах боловч ногдол ашгийг уг эргэлтээс гаргах өдрөөс өмнө тухайн байгууллагын саналаар төлнө гэж үзье. Ийм хэрэглүүр нь эргэлтээс гаргах дүнгийн өнөөгийн үнэ цэнэтэй тэнцүү өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсэг бүхий нийлмэл санхүүгийн хэрэглүүр юм. Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн бууралтын нөлөөг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрч, хүүний зардал гэж ангилна. Харин цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсэгтэй холбоотойгоор төлсөн аливаа ногдол ашгийг ашиг, алдагдлын хуваарилалт байдлаар хүлээн зөвшөөрнө. Эргэлтээс гаргалт нь зайлшгүй биш боловч эзэмшигчийн сонголтоос хамаарах бол эсвэл уг давуу эрхтэй хувьцаа нь тогтмол дүнтэй тэнцүү байхаар эсвэл суурь хувьсагчийн (жишээ нь; бараа бүтээгдэхүүн) өөрчлөлтөнд үндэслэсэн дүнтэй тэнцүү байхаар тооцоолсон тогтмол бус тооны энгийн хувьцаанд заавал хөрвөхөөр бол дээрхтэй ижил арга хандлагыг хэрэглэнэ. Харин аливаа төлөөгүй ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг тухайн эргэлтээс гаргах дүн дээр нэмдэг бол уг хэрэглүүрийг бүхэлд нь өр төлбөр гэж үзнэ. Иймтохиолдолд аливаа ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг хүүний зардал гэж ангилна.

*Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийг харилцан суутгаж, цэвэр дүн гаргалт (47-55-р параграф)*

МЗУ63. Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийг харилцан суутгаж, цэвэр дүнг гаргахын тулд байгууллага нь одоогоор уг хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг харилцан суутгаж, цэвэр дүн гаргах хууль ёсны хүчин төгөлдөр эрхтэй байх ёстой. Цэвэр дүнгээр тооцох мастер хэлцэл буюу зарим хэлбэрийн баталгаагүй өр гэх мэт тохиолдолд байгууллага нь хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах нөхцөлт эрхтэй байж болох бөгөөд ийм эрх нь зөвхөн ирээдүйн зарим үйл явдал гарч тохиолдсон, ихэвчлэн нөгөө тал үүргээ үл биелүүлсэн үед хууль ёсоор хүчин төгөлдөр хэрэгждэг. Ийм учраас ийм хэлцэл нь харилцан суутгаж, цэвэр дүн гаргах нөхцлийг хангадаггүй.

МЗУ64. Өөр хэрэглүүрийн шинж чанаруудыг гаргахын тулд олж авсан ба эзэмшсэн тусдаа санхүүгийн хэрэглүүрүүдийн бүлэг буюу “зохиомол хэрэглүүр” гэж нэрлэгдэх хэрэглүүрт зориулсан тусгай арга хандлагыг энэ Стандартад авч үзээгүй. Жишээлбэл; хөвөх төлбөрүүдийг хүлээн авах ба тогтмол төлбөрүүдийг төлөх шинж бүхий хүүний түвшний своптой хөвөх хүүтэй урт хугацаат өр нэгдсэнээр тогтмол хүүтэй урт хугацаат өрийг зохион бий болгодог. “Зохиомол хэрэглүүр”-ийг хамтран бүрдүүлдэг бие даасан санхүүгийн хэрэглүүр нэг бүр нь өөрийн нөхцөл ба болзлуудын дагуу гэрээний эрх буюу үүргийг илэрхийлдэг бөгөөд тэдгээрийг тус тусад нь шилжүүлэн өгөх буюу барагдуулж болох юм. Санхүүгийн хэрэглүүр нэг бүр нь бусад санхүүгийн хэрэглүүрүүдийн өртөж болох эрсдлээс өөр байж болох эрсдэлд өртдөг. Иймээс 47-р параграфт заасан харилцан суутгаж,

## САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОЛИЛУУЛГА

цэвэр дүнг гаргах шалгуурыг хангаагүй л бол “зохиомол хэрэглүүр”-т багтсан нэг санхүүгийн хэрэглүүр нь хөрөнгө, нөгөө хэрэглүүр нь өр төлбөр байх тохиолдолд тэдгээрийг харилцан суутгаж, тухайн байгууллагын санхүүгийн байдлын тайланд цэвэр сууриар толилуулахгүй.



## Хавсралт Б

### Хоршоон дахь Гишүүдийн Хувь Оролцоо ба Адилтгах Хэрэглүүрүүд

*Энэ Хавсралт нь УСНББОУС 28-ын салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.*

#### Танилцуулга

- Б1. Эдийн засаг буюу нийгмийн нийтлэг хэрэгцээ шаардлагаа хангахын тулд бүлэг хувь хүмүүс нь хоршоо болон адилтгах бусад байгууллагуудыг үүсгэн байгуулдаг. Үндэсний хуулиуд нь хамтын бизнесийн үйл ажиллагааны замаар (өөртөө туслах зарчмаар) өөрийн гишүүдийнхээ эдийн засгийн байдлыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх нийгмийн хүчин чармайлт гэж хоршоог ихэвчлэн тодорхойлдог. Хоршоон дахь гишүүдийн хувь оролцоо нь ихэвчлэн гишүүдийн хувьцаа, нэгж хэсэг буюу түүнтэй адил төсөөтэй шинж чанартай байдаг бөгөөд цаашид “гишүүдийн хувь оролцоо” гэж нэрлэнэ. Энэхүү Хавсралтыг тухайн байгууллага дахь гишүүдийн өмчлөлийн хувь оролцоог нотлох уг хоршооны гишүүдэд гаргасан санхүүгийн хэрэглүүрт мөрдөх бөгөөд байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрээр барагдуулах буюу барагдуулж болох санхүүгийн хэрэглүүрт даган мөрдөхгүй.
- Б2. УСНББОУС 28 нь санхүүгийн хэрэглүүрийг санхүүгийн өр төлбөр эсвэл цэвэр хөрөнгө/өмч гэж ангилах зарчмуудыг тогтоодог. Тухайлбал; буцаах эрхтэй хэрэглүүрийг түүний гаргагчид мөнгө буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр буцаан өгөхийг эзэмшигчид зөвшөөрдөг буцаах эрхтэй хэрэглүүрийн ангилалд тэдгээр зарчмуудыг мөрдөнө. Хоршоон дахь гишүүдийн хувь оролцоо болон адилтгах хэрэглүүрт эдгээр зарчмуудыг мөрдөхөд төвөгтэй байдаг. Гишүүдийн хувь оролцоо болон тодорхой шинж бүхий адилтгах хэрэглүүрүүдэд УСНББОУС 28-ын зарчмуудын мөрдөлт, түүнчлэн өр төлбөр эсвэл цэвэр хөрөнгө/өмч гэсэн ангилалд тэдгээр шинжүүд нөлөө үзүүлэх нөхцөл байдлыг үлгэрчлэн харуулахын тулд энэхүү заавар удирдамжийг бэлтгэсэн.
- Б3. Олон санхүүгийн хэрэглүүр, үүн дотроо гишүүдийн хувь оролцоо нь саналын эрх, түүнчлэн ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтанд оролцох эрх гэх мэт өмчийн хэрэглүүрийн шинж чанаруудтай байдаг. Зарим санхүүгийн хэрэглүүр нь мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгөөр эргэлтээс гаргахыг шаардах эрхийг эзэмшигчдээ олгодог боловч тухайн санхүүгийн хэрэглүүрийг эргэлтээс гаргах эсэх талаархи хязгаарлалтыг тусгасан буюу хязгаарлалтанд захирагддаг байж болох юм. Санхүүгийн хэрэглүүрийг өр төлбөр эсвэл цэвэр хөрөнгө/өмч гэж ангилах эсэхийг тодорхойлохдоо эргэлтээс гаргах эдгээр нөхцлүүдийг хэрхэн үнэлэхийг дараах параграфуудад тайлбарласан.

**Хоршоон дахь гишүүдийн хувь оролцоо болон адилтгах хэрэглүүрт УСНББОУС-ыг мөрдөх**

- Б4. Санхүүгийн хэрэглүүрийг эргэлтээс гаргахыг шаардах түүний эзэмшигчийн гэрээний эрх (үүн дотроо, хоршоон дахь гишүүдийн хувь оролцоо) нь дангаараа тухайн санхүүгийн хэрэглүүрийг санхүүгийн өр төлбөр гэж ангилахыг шаардахгүй. Харин тухайн байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийг санхүүгийн өр төлбөр эсвэл өмчийн хэрэглүүр гэж ангилах өөрийн ангиллыг тодорхойлохдоо тэрхүү санхүүгийн хэрэглүүрийн бүх нөхцөл, болзлыг харгалзан үзэх ёстой. Эдгээр нөхцөл, болзолд уг ангиллын өдрөөр хүчин төгөлдөр үйлчилж буй тухайн орон нутгийн холбогдох хууль, зохицуулалт болон тэрхүү байгууллагыг удирдан зохицуулах дүрэм хамаарах боловч тэдгээр хууль, зохицуулалт, дүрэмд оруулахаар хүлээгдэж буй ирээдүйн нэмэлт өөрчлөлтүүд хамаарахгүй.
- Б5. Хэрэв гишүүд нь эргэлтээс гаргахыг шаардах эрхгүй бол өмчийн хэрэглүүр гэж ангилах байсан гишүүдийн хувь оролцоо нь Б6, Б7-р параграфт заасан нөхцлүүд хангагдсан үед эсвэл УСНББОУС 28-ын 15 ба 16-р параграфт эсвэл 17 ба 18-р параграфт заасан бүх шинжүүдтэй бөгөөд нөхцлүүдийг биелүүлэх тохиолдолд тэдгээр гишүүдийн хувь оролцоо нь өмчийн хэрэглүүр болно. Гишүүд нь үйлчлүүлэгч байдлаар оролцох тохиолдолд үүсэх хугацаагүй хадгаламж, үүн дотроо харилцах данс, хадгаламжийн данс болон адилтгах гэрээ нь тухайн байгууллагын санхүүгийн өр төлбөр болох юм.
- Б6. Байгууллага нь гишүүдийн хувь оролцоог эргэлтээс гаргахаас татгалзах нөхцөлт бус эрхтэй бол тэдгээр гишүүдийн хувь оролцоо нь өмчийн хэрэглүүр болно.
- Б7. Орон нутгийн хууль, зохицуулалт буюу тухайн байгууллагыг удирдан зохицуулах дүрэм нь гишүүдийн хувь оролцооны эргэлтээс гаргалтанд янз бүрийн хориг хязгаарлалтыг, жишээлбэл, нөхцөлт бус хязгаарлалт эсвэл төлбөрийн чадварын шалгуурт үндэслэсэн хязгаарлалтыг тавьж болох юм. Хэрэв орон нутгийн хууль, зохицуулалт, байгууллагыг удирдан зохицуулах дүрмээр гишүүдийн хувь оролцоонд нөхцөлт бус хязгаарлалт тавьдаг бол тэдгээр гишүүдийн хувь оролцоо нь өмчийн хэрэглүүр болно. Гэвч орон нутгийн хууль, зохицуулалт буюу тухайн байгууллагыг удирдан зохицуулах дүрмийн заалтууд нь төлбөрийн чадварын хязгаарлалт гэх мэт нөхцөл зөвхөн хангагдсан (эсвэл хангагдаагүй) тохиолдолд уг гишүүдийн хувь оролцоог өмчийн хэрэглүүр гэж ангилахад хүргэхгүй.
- Б8. Нөхцөлт бус хориг нь бүх эргэлтээс гаргалтыг хориглодог туйлын шинжтэй байж болно. Эргэлтээс гаргалт нь гишүүдийн хувь оролцооны тоо буюу гишүүдийн хувь оролцоогоор төлөгдсөн капиталын дүнг тусгайлан тогтоосон түвшнээс бага болгоход хүргэх зөвхөн тийм тохиолдолд гишүүдийн хувь оролцооны эргэлтээс гаргалтыг хязгаарладаг хэсэгчилсэн нөхцөлт бус хориг байж болно. Байгууллага нь Б6-р параграфт заасанчлан, эргэлтээс гаргахаас татгалзах нөхцөлт бус эрхтэй эсвэл гишүүдийн хувь оролцоо нь УСНББОУС 28-ын 15 ба 16-р параграфт эсвэл

17 ба 18-р параграфт заасан бүх шинжүүдтэй бөгөөд нөхцлүүдийг биелүүлэхээс бусад тохиолдолд уг эргэлтээс гаргалтыг хязгаарлах хоригоос хэтэрч илүү гарсан гишүүдийн хувь оролцоо нь өр төлбөр болох юм. Зарим тохиолдолд эргэлтээс гаргах хориг хязгаарлалтанд захирагдах гишүүдийн хувь оролцооны тоо буюу гишүүдийн хувь оролцоогоор төлөгдсөн капиталын дүн нь цаг хугацааны явцад өөрчлөгдөж болох юм. Эргэлтээс гаргалтанд тавигдах хоригийн ийм өөрчлөлт нь санхүүгийн өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн хооронд шилжүүлэлт хийхэд хүргэдэг.

- Б9. Анх хүлээн зөвшөөрөх үед байгууллага нь өөрийн эргэлтээс гаргах санхүүгийн өр төлбөрийг түүний бодит үнэ цэнээр хэмждэг. Эргэлтээс гаргах шинж бүхий гишүүдийн хувь оролцооны хувьд байгууллага нь түүнийг удирдан зохицуулдаг дүрэм буюу холбогдох хуулийн эргэлтээс гаргах заалтуудын дагуу төлөх бөгөөд тухайн дүнг төлөхийг шаардаж болох хамгийн эхний өдрөөс эхлэн дискаунтчилсан хамгийн их дүнгээс багагүй дүнгээр тэрхүү эргэлтээс гаргах санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийг хэмжинэ (Жишээ 3-ыг үзнэ үү).
- Б10. УСНББОУС 28-ын 40-р параграфтаар шаардсанчлан, өмчийн хэрэглүүрийн эзэмшигчдэд олгох хуваарилалтыг аливаа орлогын татварын хэмнэлтийг хассан цэвэр дүнгээр цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрдөг. Санхүүгийн өр төлбөр гэж ангилсан санхүүгийн хэрэглүүртэй холбоотой хүү, ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт, бусад өгөөж нь тэдгээрийн төлсөн дүнг хуулийн хувьд ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт, хүү болон бусад байдлаар нэрлэсэн эсэхээс үл хамааран зардал болно.
- Б11. Эргэлтээс гаргахыг хориглох хязгаарлалтын өөрчлөлт нь санхүүгийн өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн хооронд шилжүүлэлт хийхэд хүргэдэг тохиолдолд тухайн байгууллага нь уг шилжүүлэлтийн дүн, хугацаа, учир шалтгааныг тусад нь тодруулна.
- Б12. Өмнөх параграфуудын мөрдөлтийг дараах жишээнд үлгэрчлэн харуулав.

### **Үлгэрчилсэн жишээ**

Эдгээр жишээнүүд нь бүх тохиолдлыг хамарсан иж бүрэн жагсаалт биш; өөр бусад нөхцөл байдал байх боломжтой юм. Харин жишээ бүр нь түүнд заасан нөхцлөөс өөр бусад, тухайлбал, тухайн санхүүгийн хэрэглүүрийг санхүүгийн өр төлбөр гэж ангилахыг шаардах, түүнчлэн санхүүгийн хэрэглүүр нь УСНББОУС 28-ын 15, 16-р параграфт эсвэл 17, 18-р параграфт заасан бүх шинжүүдгүй буюу нөхцлүүдийг хангахгүй байх тийм нөхцөл заалт байхгүй гэж үзнэ.

*Эргэлтээс гаргалтаас татгалзах нөхцөлт бус эрх (Б6-р параграф)*

#### **Жишээ 1**

##### *Нөхцөл*

- Б13. Зөвхөн тухайн байгууллагын хүсэл санаачлагаар эргэлтээс гаргаж болно гэж уг байгууллагын дүрэмд заасан. Тус дүрэм нь уг нэг талын

санаачлагын талаархи цаашдын баталгаа эсвэл хязгаарлалтаар хангахгүй. Хэдийгээр удирдах зөвлөл нь эргэлтээс гаргахаас татгалзах эрхтэй боловч уг байгууллага нь гишүүдийн хувь оролцоог эргэлтээс гаргахаас татгалзаж байсан түүхгүй юм.

*Ангилал*

- Б14. Байгууллага нь эргэлтээс гаргахаас татгалзах нөхцөлт бус эрхтэй бөгөөд гишүүдийн хувь оролцоо нь өмчийн хэрэглүүр юм. УСНББОУС 28 нь тухайн санхүүгийн хэрэглүүрийн нөхцөлд үндэслэн ангиллын зарчмуудыг тогтоодог бөгөөд өөрийн хүсэл зоригоор төлбөр хийдэг түүх буюу санал төлөвлөгөө нь өр төлбөрийн ангиллыг өөрчлөхгүй гэдгийг онцлон тэмдэглэсэн. УСНББОУС 28-ын МЗУ50-р параграфт дараах байдлаар заасан:

Давуу эрхтэй хувьцааг эргэлтээс үл гаргах бол түүнд хамаарах бусад эрхүүдээр зохих ангиллыг тодорхойлно. Ийм ангилал нь гэрээ хэлцлийн мөн чанар, санхүүгийн өр төлбөр ба өмчийн хэрэглүүрийн тодорхойлолтын үнэлгээнд үндэслэдэг. Хуримтлалтай эсвэл хуримтлалгүй эсэхээс үл хамааран давуу эрхтэй хувьцаа эзэмшигчдэд олгох хуваарилалт нь тухайн гаргагчийн санал хүслээс хамаардаг тохиолдолд уг хувьцаа нь өмчийн хэрэглүүр болно. Давуу эрхтэй хувьцааг өмчийн хэрэглүүр эсвэл санхүүгийн өр төлбөр гэж ангилах ангилалд тухайлбал, дараах зүйлс нөлөөлөхгүй. Үүнд:

- (а) Хуваарилалт хийж байсан түүх;
- (б) Ирээдүйд хуваарилалт хийх төлөвлөгөө;
- (в) Хэрэв хуваарилалт хийхгүй бол тухайн гаргагчийн энгийн хувьцааны үнэд үзүүлэх боломжит сөрөг нөлөө (хэрэв давуу эрхтэй хувьцаанд ногдол ашиг хуваарилаагүй бол энгийн хувьцаанд ногдол ашиг төлөхийг хязгаарласны улмаас);
- (г) Гаргагчийн нөөцийн дүн;
- (д) Тайлант үеийн ашиг, алдагдлын талаархи гаргагчийн хүлээлт; эсвэл
- (е) Тухайн тайлант үеийн ашиг, алдагдлын дүндээ уг гаргагч нөлөөлөх боломжит байдал эсвэл ийм боломжгүй байдал.

**Жишээ 2**

*Нөхцөл*

- Б15. Зөвхөн тухайн байгууллагын хүсэл санаачлагаар эргэлтээс гаргаж болно гэж уг байгууллагын дүрэмд заасан. Гэвч тус байгууллага нь төлбөрийн чадвар буюу нөөцийн талаархи тухайн орон нутгийн зохицуулалтыг зөрчихгүйгээр төлбөр хийх чадваргүй байхаас бусад тохиолдолд эргэлтээс гаргах хүсэлтийн зөвшөөрөл автоматаар олгогдоно гэж уг байгууллагын дүрэмд заасан байдаг.

*Ангилал*

- Б16. Байгууллага нь эргэлтээс гаргахаас татгалзах нөхцөлт бус эрхгүй бөгөөд гишүүдийн хувь оролцоог санхүүгийн өр төлбөр гэж ангилдаг. Дээр дурдсан хязгаарлалтууд нь өр төлбөрийг барагдуулах тухайн байгууллагын чадвар боломжинд үндэслэдэг. Төлбөрийн чадвар буюу

нөөцийн шаардлагууд зөвхөн биелэгдэхгүй байгаа бөгөөд биелэгдэх хүртэлх хугацаанд эдгээр нь эргэлтээс гаргалтыг хязгаарладаг. Иймээс эдгээр нь УСНББОУС 28-д заасан зарчмуудын дагуу санхүүгийн хэрэглүүрийг өмчийн хэрэглүүр гэж ангилахад хүргэхгүй. УСНББОУС 28-ын МЗУ49-р параграфт дараах байдлаар заасан:

Давуу эрхтэй хувьцааг янз бүрийн эрхтэйгээр гаргаж болно. Давуу эрхтэй хувьцаа нь санхүүгийн өр төлбөр эсвэл өмчийн хэрэглүүр эсэхийг тодорхойлохдоо, гаргагч нь уг давуу эрхтэй хувьцаанд санхүүгийн өр төлбөрийн үндсэн шинж чанарууд байгаа эсэхийг тогтоох үүднээс тэрхүү хувьцаанд хамаарах тусгай эрхүүдийг үнэлж үздэг. Жишээлбэл; тодорхой заасан хугацаанд эсвэл эзэмшигчийн сонголтоор эргэлтээс гаргах боломжтой давуу эрхтэй хувьцаа нь санхүүгийн өр төлбөр юм. Яагаад гэвэл, гаргагч нь уг хувьцааны эзэмшигчид санхүүгийн хөрөнгө шилжүүлэх үүрэг хүлээж байна. *Мөнгө сангийн хүрэлцээгүй байдал, хууль эрх зүйн хязгаарлалт, хангалттай бус ашиг, хүрэлцээгүй нөөц зэргийн улмаас гэрээгээр шаардсан хугацаанд давуу эрхтэй хувьцаагаа эргэлтээс гаргах үүрэгээ тухайн гаргагч биелүүлэх чадваргүй байдал нь түүнийг уг үүрэгээс чөлөөлөхгүй.* [Онцолж тэмдэглэсэн]

*Эргэлтээс гаргахыг хориглох (Б7 ба Б8-р параграф)*

### **Жишээ 3**

#### *Нөхцөл*

Б17. Хоршоо нь гишүүддээ янз бүрийн хугацаанд өөр өөр дүнтэй хувьцааг дараах байдлаар гаргасан:

- (а) 20X1 оны 01-р сарын 01. Нэгжийн 10ТН-ээр 100,000 ширхэг хувьцаа (1,000,000)ТН;
- (б) 20X2 оны 01-р сарын 01. Нэгжийн 20ТН-ээр 100,000 ширхэг хувьцаа (гаргасан хувьцааны нийт дүн 3,000,000ТН болохын тулд 2,000,000ТН-ийг нэмж гаргасан).

Хувьцааг шаардсан үед тэдгээрийн анх гаргасан дүнгээр эргэлтээс гаргаж болно.

Б18. Хуримтлагдсан эргэлтээс гаргалт нь дурын хугацаанд эргэлтэнд буй түүний гишүүдийн хувь оролцооны хамгийн их тооны 20 хувиас хэтрэхгүй байна гэж уг байгууллагын дүрэмд заасан. 20X2 оны 12 дугаар сарын 31-нд байгууллага нь эргэлтэнд нийт 200,000 ширхэг хувьцаатай байсан бөгөөд энэ нь дурын хугацаанд эргэлтэнд байсан гишүүдийн хувь оролцооны хамгийн их тоо бөгөөд өнгөрсөн хугацаанд ямар нэг хувь оролцоог эргэлтээс гаргаж байгаагүй. 20X3 оны 01 дүгээр сарын 01-нд байгууллага нь өөрийн удирдан зохицуулах дүрэмдээ нэмэлт өөрчлөлт оруулж, хуримтлагдсан эргэлтээс гаргалтын зөвшөөрөгдсөн түвшинг дурын хугацаанд эргэлтэнд буй түүний гишүүдийн хувь оролцооны хамгийн их тооны 25 хувь болтол нэмэгдүүлсэн.

*Ангилал*

Удирдан зохицуулах дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулахын өмнө

- Б19. Эргэлтээс гаргалтын хориг хязгаарлалтаас давсан гишүүдийн хувь оролцоо нь санхүүгийн өр төлбөр юм. Тус хоршоо нь энэхүү санхүүгийн өр төлбөрийг түүний анх гаргах үеийн бодит үнэ цэнээр хэмждэг. Эдгээр хувь оролцоог эзэмшигчийн шаардлагын дагуу эргэлтээс гаргах учраас тус хоршоо нь дараах байдлаар заасан УСНББОУС 29-ийн 52-р параграфтаар шаардсанчлан, ийм санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлно: “Шаардах шинж бүхий санхүүгийн өр төлбөрийн (жишээлбэл; хугацаагүй хадгаламжийн) бодит үнэ цэнэ нь уг шаардлагаар төлөх дүнгээс багагүй байна...”. Иймээс хоршоо нь эргэлтээс гаргах нөхцлийн дагуу шаардсанаар төлөх хамгийн их дүнгээр санхүүгийн өр төлбөр гэж ангилна.
- Б20. 20X1оны 01 дүгээр сарын 01-нд эргэлтээс гаргах нөхцлийн дагуу төлөх хамгийн их дүн нь нэгжийн 10ТН-ийн үнэтэй 20,000 ширхэг хувьцаа байсан тул уг байгууллага нь 200,000ТН-ээр санхүүгийн өр төлбөр, 800,000ТН-ээр өмчийн хэрэглүүр гэж ангилна. Гэвч нэгжийн 20ТН бүхий хувь оролцооны шинэ гаргалтын улмаас 20X2 оны 01 дүгээр сарын 01-нд уг эргэлтээс гаргах нөхцлийн дагуу төлөх хамгийн их дүн нь нэгжийн 20ТН-ийн үнэтэй 40,000 ширхэг хувьцаа болж өссөн. Нэгжийн 20ТН-ийн үнэтэй нэмэлт хувь оролцооны гаргалт нь шинэ өр төлбөрийг үүсгэх бөгөөд түүнийг анх гаргах үед бодит үнэ цэнээр нь хэмжинэ. Эдгээр хувь оролцоог гаргасны дараах өр төлбөр нь нийт хувь оролцооны гаргалтын (200,000 ширхэгийн) 20 хувь буюу нэгжийн 20ТН-ээр хэмжсэн 800,000ТН байна. Энэ нь 600,000ТН-ийн нэмэлт өр төлбөр хүлээн зөвшөөрөхийг шаарддаг. Энэ жишээнд ямар нэг олз буюу гарз хүлээн зөвшөөрөхгүй. Иймээс байгууллага нь одоо 800,000ТН-ийг санхүүгийн өр төлбөр, 2,200,000ТН-ийг өмчийн хэрэглүүр гэж ангилна. Эдгээр дүнгүүд нь 20X1 оны 01 дүгээр сарын 01-нээс 20X2 оны 12 дугаар сарын 31-ний хооронд өөрчлөгдөхгүй гэж энэ жишээнд үзсэн.

Удирдан зохицуулах дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсаны дараа

- Б21. Өөрийн удирдан зохицуулах дүрэмд өөрчлөлт оруулсны дараа тус хоршоо нь одоо эргэлтэнд байгаа хувь оролцооныхоо хамгийн ихдээ 25 хувь буюу нэгжийн 20ТН-ийн үнэтэй хамгийн ихдээ 50,000 ширхэг хувьцааг эргэлтээс гаргах шаардлагатай болно. Иймээс 20X3 оны 01 дүгээр сарын 01-нд тус хоршоо нь УСНББОУС 28-ын 52-р параграфын дагуу тодорхойлсон, эргэлтээс гаргах нөхцлийн дагуу шаардсанаар төлөх хамгийн их дүн болох 1,000,000ТН-ээр санхүүгийн өр төлбөр гэж ангилна. Иймээс уг хоршоо нь 20X3 оны 01 дүгээр сарын 01-нд 200,000ТН-ийг цэвэр хөрөнгө/өмчөөс санхүүгийн өр төлбөр болгон шилжүүлэх бөгөөд 2,000,000ТН-ийг өмчийн хэрэглүүр гэж ангилсан хэвээр үлдээнэ. Энэ жишээнд байгууллага нь уг шилжүүлэлтээр ямар нэг олз буюу гарз хүлээн зөвшөөрөхгүй.

#### Жишээ 4

##### *Нөхцөл*

- Б22. Хэрэв хувь оролцооны эргэлтээс гаргалт нь гишүүдийн хувь оролцоогоор төлөгдсөн капиталыг тэдгээр гишүүдийн хувь оролцоо болох капиталын хамгийн их дүнгийн 75 хувиас бага болтол бууруулахаар бол хоршоодын үйл ажиллагааг зохицуулах орон нутгийн хууль тогтоомж эсвэл тухайн байгууллагыг удирдан зохицуулах дүрэм нь гишүүдийн хувь оролцооны эргэлтээс гаргалтыг уг байгууллагад хориглодог. Тухайн хоршооны капиталын хамгийн их дүн нь 1,000,000ТН байсан. Тайлант үеийн эцэст капиталын төлөгдсөн үлдэгдэл нь 900,000ТН байсан.

##### *Ангилал*

- Б23. Энэ тохиолдолд 750,000ТН-ийг өмчийн хэрэглүүр, 150,000ТН-ийг санхүүгийн өр төлбөр гэж ангилна. Өмнө дурдсан параграфтаас гадна УСНББОУС 28-ын 22(б) параграфт дараах байдлаар заасан байдаг:

...Тухайн гаргагчид мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгөөр буцаан өгөх эрхийг эзэмшигчдээ олгодог бөгөөд 15, 16-р параграф эсвэл 17, 18-р параграфуудын дагуу өмчийн хэрэглүүр гэж ангилсан хэрэглүүрүүдээс бусад санхүүгийн хэрэглүүр ('буцаах эрхтэй хэрэглүүр') нь санхүүгийн өр төлбөр юм. Мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийн дүнг нь өсөх эсвэл буурах боломжтой индекс болон бусад зүйлсэд үндэслэн тодорхойлдог байлаа ч гэсэн уг санхүүгийн хэрэглүүр нь санхүүгийн өр төлбөр болно. 15, 16-р параграф эсвэл 17, 18-р параграфуудын дагуу өмчийн хэрэглүүр гэж ангилсан хэрэглүүрүүдээс бусад хэрэглүүрийг түүний гаргагчид мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгөөр буцаан өгөх сонголт тухайн эзэмшигчид байх нь уг буцаах эрхтэй хэрэглүүр санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангана гэсэн үг юм.

- Б24. Энэ жишээнд дурдсан, эргэлтээс гаргалтын хориг хязгаарлалт нь УСНББОУС 28-ын 23-р параграф болон МЗУ49-р параграфт заасан хязгаарлалтаас өөр юм. Эдгээр хязгаарлалтууд нь санхүүгийн өр төлбөрийн хувьд төлөх ёстой дүнг барагдуулах уг байгууллагын чадвар боломжинд тавигдах хязгаарлалт юм. Өөрөөр хэлбэл, энэ нь зөвхөн тусгай нөхцөл хангагдсан үед өр төлбөрийг барагдуулахаас сэргийлэх хязгаарлалт юм. Нөгөө талаас, гишүүдийн хувь оролцоог эргэлтээс гаргах тухайн байгууллагын чадвар боломжоос (түүний мөнгөн хөрөнгийн нөөц, ашиг буюу хуваарилж болох нөөцөөс) үл хамааран тодорхой дүнгээс давсан эргэлтээс гаргалтын хувьд тавигдах нөхцөлт бус хориг хязгаарлалтыг энэ жишээнд авч үзсэн. Үнэн хэрэгтээ, эргэлтээс гаргалтанд тавигдах хориг хязгаарлалт нь төлөгдсөн капиталын тодорхой дүнгээс илүү дүнгээр эргэлтээс гаргахын тулд аливаа санхүүгийн өр төлбөр үүсгэхээс тухайн байгууллагыг сэргийлдэг. Иймээс эргэлтээс гаргалтын хориг хязгаарлалтанд захирагдах хувь оролцооны хэсэг нь санхүүгийн өр төлбөр биш юм. Гишүүн нэг бүрийн хувь оролцоог тус тусад нь эргэлтээс гаргаж болох боловч эргэлтэнд байгаа нийт хувь оролцооны зарим хэсэг нь тухайн байгууллага татан буугдахаас бусад аливаа нөхцөлд эргэлтээс гаргах боломжгүй байдаг.

## Жишээ 5

### *Нөхцөл*

- Б25. Энэ жишээний нөхцөл нь Жишээ 4-д дурдсан нөхцөлтэй ижил байна. Мөн түүнчлэн, байгууллагын эзэмшиж буй мөнгө ба богино хугацаат хөрөнгө оруулалтын дүн нь тогтоосон дүнгээс илүү байхаас бусад тохиолдолд тайлант үеийн эцэст тухайн орон нутгийн хууль тогтоомжинд заасан төлбөрийн чадварын шаардлагууд нь гишүүдийн аливаа хувь оролцоог уг байгууллага эргэлтээс гаргахыг хориглодог. Тайлант үеийн эцэс дэх эдгээр төлбөрийн чадварын шаардлагуудын үр дүнд тухайн байгууллага нь гишүүдийн хувь оролцоог эргэлтээс гаргахын тулд 50,000ТН-ээс илүү дүнг төлж болохооргүй байна.

### *Ангилал*

- Б26. 4-р жишээнд дурдсантай адилаар байгууллага нь 750,000ТН-ийг өмчийн хэрэглүүр, 150,000ТН-ийг санхүүгийн өр төлбөр гэж ангилна. Яагаад гэвэл, өр төлбөр гэж ангилсан дүн нь төлбөрийн чадварын болон бусад нөхцлүүд биелэгдэхгүй бол эргэлтээс гаргахыг хориглох ба тэдгээр нөхцөл зөвхөн биелэгдсэн тохиолдолд эргэлтээс гаргахыг зөвшөөрдөг нөхцөлт хязгаарлалтанд биш, харин эргэлтээс гаргахаас татгалзах уг байгууллагын нөхцөлт бус эрхэд үндэслэдэг. Энэ тохиолдолд УСНББОУС 28-ын 23-р пагараф ба МЗУ49-р параграфын нөхцлүүдийг мөрдөнө.

## Жишээ 6

### *Нөхцөл*

- Б27. Шинэ буюу одоогийн гишүүдэд сүүлийн гурван жилийн хугацаанд нэмэлт хувь оролцоог гаргаснаар хүлээн авсан мөнгөн орлогын дүн хүртэлх хэмжээнээс бусад байдлаар гишүүдийн хувь оролцоог эргэлтээс гаргахыг тухайн байгууллагын дүрмээр хориглодог. Гишүүдийн хувь оролцооны гаргалтаас хүлээн авсан мөнгөн орлогыг эргэлтээс гаргах хүсэлт ирүүлсэн гишүүдийн хувь оролцоог эргэлтээс гаргахад ашиглан зарцуулах ёстой. Сүүлийн гурван жилийн туршид гишүүдийн хувь оролцоог гаргаснаар хүлээн авсан мөнгөн орлого нь 12,000ТН байсан бөгөөд аль нэг гишүүний хувь оролцоог энэ хугацаанд эргэлтээс гаргаагүй.

### *Ангилал*

- Б28. Байгууллага нь гишүүдийн 12,000ТН-ийн хувь оролцоог санхүүгийн өр төлбөр гэж ангилна. Жишээ 4-д дурдсан дүгнэлтийн дагуу эргэлтээс гаргалтын нөхцөлт бус хориг хязгаарлалтанд захирагдах гишүүдийн хувь оролцооны хэсэг нь санхүүгийн өр төлбөр биш юм. Ийм нөхцөлт бус хоригийг сүүлийн гурван жилээс өмнө гаргасан хувьцааны мөнгөн орлоготой тэнцүү дүнд хэрэглэх тул энэхүү дүнг өмчийн хэрэглүүр гэж ангилна. Харин сүүлийн гурван жилийн хугацаанд гаргасан аливаа хувь оролцооны мөнгөн орлоготой тэнцүү дүн нь эргэлтээс гаргалтын нөхцөлт бус хоригт захирагдахгүй юм. Иймээс сүүлийн гурван жилийн хугацаанд



гишүүдийн хувь оролцооны гаргалтаас хүлээн авсан мөнгөн орлого нь гишүүдийн хувь оролцооны эргэлтээс гаргалтанд цаашид ашиглах боломжгүй болох хүртэл санхүүгийн өр төлбөрийг үүсгэнэ. Үүний үр дүнд тухайн байгууллага нь сүүлийн гурван жилийн хугацаанд гаргасан хувьцааны мөнгөн орлогоос тэрхүү хугацааны аливаа эргэлтээс гаргалтыг хассан цэвэр дүнтэй тэнцүү хэмжээний санхүүгийн өр төлбөртэй байна.

## **Жишээ 7**

### *Нөхцөл*

- Б29. Байгууллага нь хоршоо хэлбэрийн банк юм. Хоршоо хэлбэрийн банкуудын үйл ажиллагааг зохицуулдаг орон нутгийн хуулинд тухайн байгууллагын нийт “эх үүсвэр”-ийн (гишүүдийн хувь оролцооны дансыг хамруулан тусгахын тулд уг хуулинд ийм нэр томъёог ашигласан) наад зах нь 50 хувь нь гишүүдийн төлсөн капиталын хэлбэртэй байх ёстой гэж заасан. Энэхүү зохицуулалтанд заасанчлан, хоршоо хэлбэрийн банкны бүх эх үүсвэр нь гишүүдийн хувь оролцоо байвал тэдгээрийг бүгдийг нь эргэлтээс гаргаж болох юм. 20X1 оны 12 дугаар сарын 31-нд байгууллага нь нийт 200,000ТН-ийн эх үүсвэртэй байсан бөгөөд түүний 125,000ТН нь гишүүдийн хувь оролцоо дансыг илэрхийлж байна. Гишүүдийн хувь оролцооны дансны нөхцөл нь өөрийн хүсэлт шаардлагын дагуу хувь оролцоогоо эргэлтээс гаргах боломжийг эзэмшигчид олгодог бөгөөд тухайн байгууллагын дүрэмд эргэлтээс гаргах талаар заасан ямар нэг хязгаарлалт байдаггүй.

### *Ангилал*

- Б30. Энэхүү жишээнд гишүүдийн хувь оролцоог санхүүгийн өр төлбөр гэж ангилна. эргэлтээс гаргалтын хориг хязгаарлалт нь УСНББОУС 28-ын 23-р параграф болон МЗУ49-р параграфт заасан хязгаарлалттай ижил юм. Тухайн хязгаарлалт нь санхүүгийн өр төлбөрийн хувьд төлөх ёстой дүнг барагдуулах уг байгууллагын чадвар боломжинд тавигдах хязгаарлалт юм. Өөрөөр хэлбэл, энэ нь зөвхөн тусгай нөхцөл хангагдсан үед өр төлбөрийг барагдуулахаас сэргийлэх хязгаарлалт юм. Ялангуяа өөрийн бусад бүх өр төлбөр (75,000ТН)-ийг буцаан төлвөл гишүүдийн хувь оролцоог нийт дүн (125,000ТН)-ээр эргэлтээс гаргахыг тухайн байгууллагаас шаардаж болох юм. Иймээс эргэлтээс гаргалтанд тавигдах хориг хязгаарлалт нь гишүүдийн хувь оролцооны тогтоосон тоо хэмжээ буюу төлөгдсөн капиталын тодорхой дүнгээс илүү дүнгээр эргэлтээс гаргахын тулд аливаа санхүүгийн өр төлбөр үүсгэхээс тухайн байгууллагыг сэргийлдэг. Энэ нь нөхцөл хангагдах, өөрөөр хэлбэл, бусад өр төлбөрийг барагдуулах хүртэл зөвхөн эргэлтээс гаргалтыг хойшлуулахыг уг байгууллагад зөвшөөрдөг. Энэ жишээн дэх гишүүдийн хувь оролцоо нь эргэлтээс гаргалтын нөхцөлт бус хориг хязгаарлалтанд захирагдахгүй бөгөөд иймээс түүнийг санхүүгийн өр төлбөр гэж ангилна.

## **Хавсралт В**

### **Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт**

[Хассан]

## Дүгнэлтийн Үндэслэл

Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 28-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

### Танилцуулга

- ДҮ1. УСНББОУС 28, *Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга*-ын дүгнэлтүүдэд хүрэхдээ Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн харгалзан үзсэн зүйлсийг энэхүү Дүгнэлтийн Үндэслэлд нэгтгэн товчоолсон. Энэхүү Стандартыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан НББОУС 32, *Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга*-аас үндсэндээ бэлтгэсэн тул Дүгнэлтийн Үндэслэл нь НББОУС 32-ын гол шаардлагуудаас УСНББОУС 28 гажих зөвхөн тэдгээр талбаруудыг авч үзсэн болно.
- ДҮ2. Санхүүгийн хэрэглүүрийн энэхүү төсөл нь УСНББОУС-уудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-тай нийцүүлэхийг эрмэлзэж буй УСНББОУСЗ-ийн ажлын хөтөлбөрийн чухал хэсэг юм. Улсын сектортой холбоотой тул НББОУС 32-д харгалзан авч үзээгүй, санхүүгийн хэрэглүүрийн бусад төлөв байдлууд байгаа гэдгийг УСНББОУСЗ мэдэгдсэн. Эдгээрийг УСНББОУСЗ-ийн ирээдүйн төслүүдээр авч үзэж болох юм. Ялангуяа ирээдүйн төслүүд нь дараах зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай байж болно гэдгийг УСНББОУСЗ онцлон тэмдэглэсэн:
- Төв банкны эрхлэн гүйцэтгэдэг зарим ажил гүйлгээ;
  - Мөн чанарын хувьд санхүүгийн хэрэглүүртэй төсөөтэй бөгөөд нэг ижил эдийн засгийн үр дагавартай боловч гэрээний шинж чанаргүй хэлцлээс үүсдэг авлага ба өглөг.
- ДҮ3. Энэхүү Стандартыг боловсруулахдаа, УСНББОУСЗ нь НББОУС 32-ын одоогийн текстийг хэвээр хадгалах, бусад УСНББОУС-ын нэр томъёо ба толилуулгын шаардлагуудтай нийцэлтийг хангахын тулд өөрчлөлтийг оруулах ба улсын секторын аливаа тусгай асуудлуудыг нэмэлт Мөрдөх Заавар Удирдамжаар авч үзэхийг зөвшөөрсөн.
- ДҮ4. 2007 оны 9 дүгээр сард НББОУСЗ нь НББОУС 1, *Санхүүгийн Тайлангийн Толилуулга*-д нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд санхүүгийн тайлангийн толилуулгад “дэлгэрэнгүй орлого” гэсэн ойлголтыг нэвтрүүлсэн. УСНББОУСЗ нь НББОУС 1-ийн бусад зарим нэмэлт өөрчлөлтүүдийн дагуу дэлгэрэнгүй орлогыг хараахан авч үзээгүй байгаа тул тэдгээр нэмэлт өөрчлөлтийг УСНББОУС 28-д хамруулан тусгаагүй.

## Цар хүрээ

### *Даатгалын болон санхүүгийн баталгааны гэрээ*

ДҮ5. Гаргагч нь тухайн гэрээг хүлээн зөвшөөрч, хэмжихдээ НББОУС 39, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*-ийг мөрддөг санхүүгийн баталгааны гэрээнээс бусад бүх даатгалын гэрээг НББОУС 32 нь өөрийн цар хүрээнд хамруулдаггүй. Доор дурдсанаас бусад бүх даатгалын гэрээ нь УСНББОУС 28-ын цар хүрээнд бас хамаарахгүй:

- Байгууллага нь даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартын дагуу тухайн гэрээг даатгалын гэрээ гэж үзэх сонголт хийснээс бусад тохиолдолд санхүүгийн хэрэглүүр гэж үзэх санхүүгийн баталгааны гэрээ; ба
- Даатгалын гэрээ мөн боловч УСНББОУС 28, УСНББОУС 29, УСНББОУС 30-ын дагуу санхүүгийн хэрэглүүр гэж үзэж болох санхүүгийн эрсдлийн шилжүүлэлтийг агуулсан гэрээнүүд.

### *Санхүүгийн баталгааг санхүүгийн хэрэглүүр гэж үзэх*

ДҮ6. Гаргагч нь санхүүгийн баталгааны гэрээнд СТОУС 4-ийг мөрдөх сонголт хийснээс бусад тохиолдолд НББОУС 32-ын дагуу санхүүгийн баталгааны гэрээг санхүүгийн хэрэглүүр гэж үзвэл зохино. Хувийн хэвшлээс ялгаатай нь, санхүүгийн баталгааны олон гэрээг улсын секторт арилжааны бус ажил гүйлгээний замаар, өөрөөр хэлбэл үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр гаргадаг. Санхүүгийн тайлангийн зэрэгцүүлэгдэх байдлыг нэмэгдүүлэх ба улсын сектор дахь арилжааны бус ажил гүйлгээгээр гаргасан санхүүгийн баталгааны гэрээний ач холбогдлыг харгалзан үзсэнээр УСНББОУС3 нь ийм баталгааг санхүүгийн хэрэглүүр гэж үзэхийг санал болгосон бөгөөд байгууллагууд нь үүнийг даатгалын гэрээ гэж үзэхийг зөвшөөрдөггүй.

ДҮ7. Энэхүү саналын хариулт болгон зарим санал гаргагч нар нь арилжааны бус ажил гүйлгээгээр гаргасан санхүүгийн баталгааны гэрээг даатгалын гэрээ биш, харин санхүүгийн хэрэглүүр гэж үзэх арга хандлага тохиромжтой гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Яагаад гэвэл, арилжааны ба арилжааны бус даатгалын гэрээнүүдийн бизнесийн загвар өөр байдаг. Өөр зарим санал гаргагч нар нь СТУОС 4-д дурдсантай ижил төсөөтэй сонголтыг ашигласнаар ийм баталгааг даатгалын гэрээ эсвэл санхүүгийн хэрэглүүр гэж үзэх эсэхийг тухайн байгууллагуудад зөвшөөрөх хэрэгтэй гэсэн санал дэвшүүлсэн.

ДҮ8. Байгууллагын санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөх суурь өр төлбөр нь өөрчлөгдөхгүй учраас арилжааны эсвэл арилжааны бус ажил гүйлгээгээр гаргасан эсэхээс үл хамааран санхүүгийн баталгааны гэрээнүүдэд нэг ижил хандлагыг мөрдөх хэрэгтэй гэж УСНББОУС3 дүгнэсэн. Тодорхой нөхцөл байдлаас хамааран санхүүгийн баталгааны гэрээг даатгалын

гэрээ эсвэл санхүүгийн хэрэглүүр гэж үзэх сонголтыг тухайн байгууллагад олгох хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ зөвшөөрсөн.

ДҮ9. Байгууллага нь санхүүгийн баталгааны гэрээг даатгалын гэрээ гэж үзэх сонголт хийж болох нөхцөл байдлыг үнэлэхдээ УСНББОУСЗ нь СТОУС 4-ийн шаардлагуудыг харгалзан үзсэн. Санхүүгийн баталгааны гэрээг СТОУС 4-ийн дагуу санхүүгийн хэрэглүүр эсвэл даатгалын гэрээ гэж үзэх сонголт нь ийм гэрээг даатгалын гэрээ байдлаар авч үздэг байснаа өмнө нь тодорхой мэдэгдсэн зөвхөн тэдгээр байгууллагуудын хувьд боломжтой юм. Гэвч бүх байгууллагууд нь СТОУС 4-ийг мөрдөх аккруэл нягтлан бодох бүртгэлийг хэрэглэдэггүй гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Мөн тухайн нөхцөл байдлыг харгалзан үзэх хэрэгтэй гэдгийг тэмдэглэсэн. Тухайлбал; байгууллагууд нь аккруэл нягтлан бодох бүртгэлийг мөрддөг боловч даатгалын гэрээтэй холбоотой хөрөнгө ба өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөггүй эсвэл байгууллагууд нь аккруэл нягтлан бодох бүртгэлийг өмнө нь мөрддөггүй байсан байж болох юм. Үүний үр дүнд УСНББОУСЗ нь СТОУС 4-ийн одоогийн шаардлагууд хэт төвөгтэй бөгөөд энэ Стандартын агуулгын хүрээнд түүнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрсөн.

ДҮ10. Иймээс УСНББОУСЗ нь дараах нөхцлийг зөвшөөрсөн:

- (а) Өмнө нь даатгалын нягтлан бодох бүртгэлийг хэрэглэж байсан бөгөөд санхүүгийн баталгааны гэрээг даатгалын гэрээ гэж үзэх нягтлан бодох бүртгэлийн бодлого баримталж байсан байгууллагууд нь тэдгээр баталгааг даатгалын гэрээ эсвэл санхүүгийн хэрэглүүр гэж үзэх хандлагаа үргэлжүүлэх;
- (б) Өмнө нь даатгалын нягтлан бодох бүртгэлийг хэрэглэж байгаагүй байгууллагууд нь энэхүү Стандартыг мөрдсөн үеэс санхүүгийн баталгааны гэрээг даатгалын гэрээ эсвэл санхүүгийн хэрэглүүр гэж үзэх сонголт хийх.

Энэхүү хоёр тохиолдлын аль алины хувьд хийсэн сонголт нь эргэлт буцалтгүй байна.

ДҮ11. Санхүүгийн баталгааг гэрээ тус бүрээр авч үзэн даатгалын гэрээ гэж үзэх сонголт хийхийг байгууллагуудад зөвшөөрөх эсвэл нягтлан бодох бүртгэлийн бодлогын ерөнхий нэг сонголт хийхийг байгууллагуудаас шаардах хэрэгтэй эсэхийг УСНББОУСЗ нь харгалзан үзсэн. Эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх байгууллагууд нь өөрийн бизнесийн мөн чанарт үндэслэн санхүүгийн баталгааг даатгалын гэрээ эсвэл санхүүгийн хэрэглүүр гэж үзэх эсэхийг зөвшөөрөхийн тулд гэрээ тус бүрээр сонголт хийхийг УСНББОУСЗ нь зөвшөөрсөн.

ДҮ12. Байгууллагууд нь санхүүгийн баталгаагаа даатгалын гэрээ гэж үзэхийг тэдэнд зөвшөөрөх урьдчилсан нөхцөл бол даатгалын гэрээний хувьд тухайн байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн практик нь тодорхой шаардлагуудыг хангах явдал гэдгийг УСНББОУСЗ зөвшөөрсөн. Хэрэв байгууллага нь санхүүгийн баталгааны гэрээг даатгалын гэрээ гэж

үзэх сонголт хийсэн бол тухайн байгууллага нь СТОУС 4 эсвэл даатгалын өр төлбөрийг хамгийн бага үнэ цэнээр хэмжихийг шаарддаг үндэсний нягтлан бодох бүртгэлийн стандартын аль нэгийг мөрдөх ёстой гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. Хэрэв даатгалын өр төлбөр нь УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-ийн цар хүрээнд хамаарах бол тухайн байгууллагын даатгалын гэрээнүүдээс үүсэх мөнгөн гүйлгээ болон аливаа холбогдох мөнгөн гүйлгээний одоогийн тооцооллыг ашиглан уг хамгийн бага үнэ цэнийг тодорхойлно.

*Санхүүгийн эрсдлийг шилжүүлдэг даатгалын гэрээг санхүүгийн хэрэглүүр гэж үзэх сонголт*

ДҮ13. Даатгалын гэрээ болох ба санхүүгийн эрсдлийн шилжүүлэлт хийхэд хүргэдэг гэрээнүүдийг байгууллага нь санхүүгийн хэрэглүүр гэж тайлагнахыг УСНББОУС 15-аар зөвшөөрсөн байдаг. Даатгалын гэрээний талаархи УСНББОУС байхгүй тохиолдолд байгууллагууд нь ийм гэрээнд УСНББОУС 28-ыг мөрдөхийг зөвшөөрөх боловч заавал шаардахгүй гэж УСНББОУСЗ мэдэгдсэн.

*Гэрээний санхүүгийн баталгааг тодорхойлох*

ДҮ14. УСНББОУС 28-д санхүүгийн хэрэглүүрийг “...нэг байгууллагын хувьд санхүүгийн хөрөнгө, нөгөө байгууллагын хувьд санхүүгийн өр төлбөр эсвэл өмчийн хэрэглүүр үүсэхэд хүргэдэг аливаа гэрээ” гэж тодорхойлсон. Улсын секторт хэлцэл нь хууль ёсны бүрэн эрхээр үүсэж болох тул санхүүгийн баталгаа нь хэзээ гэрээ болох эсэхийг тогтоох нэмэлт мөрдөх заавар удирдамжийг УСНББОУСЗ боловсруулсан. УСНББОУС 28-ын цар хүрээнд хамаарахын тулд санхүүгийн баталгаа нь гэрээний хэлцлийн гол шинжүүдтэй байвал зохино гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Байгууллага нь хууль буюу бусад бүрэн эрхийн дагуу түүнд ихэвчлэн олгогддог баталгаа гаргах эрх ба тухайн гуравдагч талыг шууд буюу шууд бусаар тогтоосон эсэхээс үл хамааран гуравдагч талын ашиг тусын төлөө гаргадаг баталгааны жинхэнэ гаргалтыг ялган салгах хэрэгтэй гэж УСНББОУСЗ бас дүгнэсэн. Баталгаа гаргах хууль ёсны эрх нь өөрөө энэ Стандартын цар хүрээнд хамаардаггүй.

## **Тодорхойлолт**

*Гэрээний хэлцлүүд*

ДҮ15. Зарим улс оронд улсын секторын байгууллагууд нь албан ёсны гэрээ байгуулж чадахгүй боловч гэрээний мөн чанар бүхий хэлцэл хийдэг гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн байдаг. Тэдгээр хэлцлийг өөр нэр томъёогоор, жишээлбэл, “засгийн газрын захиалга” гэх мэтээр нэрлэж болно. Мөн чанарын хувьд эсвэл хуулийн хэлбэрийн хувьд гэрээ болох эсэхийг тогтооход байгууллагуудад туслахын тулд УСНББОУСЗ нь тухайн хэлцэл гэрээ эсвэл гэрээ биш эсэхийг үнэлэхдээ уг байгууллагын харгалзан үзвэл зохих хүчин зүйлсийг тайлбарласан нэмэлт Мөрдөх Заавар Удирдамж гаргах нь тохиромжтой гэж үзсэн.

ДҮ16. ДҮ15-д онцлон тэмдэглэсэн хэлцлүүдийг тодорхойлон тайлбарлахын тулд “заавал биелүүлэх хэлцэл” гэсэн нэр томъёог ашиглах хэрэгтэй эсэхэд анхаарал хандуулсан. “Заавал биелүүлэх хэлцэл” нэр томъёог тодорхойлоогүй боловч талуудын хувьд заавал биелэгдэх тохиролцоог илэрхийлэхийн тулд УСНББОУС-д түүнийг хэрэглэсэн боловч энэ нь баримтжуулсан гэрээний хэлбэргүй байдаг. Жишээлбэл; гэрээ байгуулах бүрэн эрхгүй засгийн газрын хоёр хэлтсийн хоорондох хэлцэл гэх мэт. УСНББОУС-уудад ашигладаг “заавал биелүүлэх хэлцэл” нэр томъёо нь ДҮ15-р параграфт тодорхойлсноос илүү өргөн хүрээтэй, цогц хэлцлийг агуулдаг, иймээс түүнийг энэхүү УСНББОУС-д хэрэглэх шаардлагагүй гэж УСНББОУС3 дүгнэсэн.

*Арилжааны бус гэрээний орлогын ажил гүйлгээ*

ДҮ17. УСНББОУС 23, *Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Татвар ба Шилжүүлэг)* нь арилжааны бус орлогын ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгө, өр төлбөрийн анхны хүлээн зөвшөөрөлт, анхны хэмжилт ба тодруулгыг тодорхойлдог. УСНББОУС3 нь энэ Стандарт ба УСНББОУС 23-ын хоорондох харилцан үйлчлэлийг авч үзсэн.

ДҮ18. Арилжааны бус орлогын ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгө, өр төлбөр нь санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр мөн эсэхийг авч үзэхдээ УСНББОУС3 нь биелэгдвэл зохих дараах үндсэн шаардлагуудыг тодорхойлсон:

- Хэлцэл нь мөн чанарын хувьд гэрээ байх; ба
- Хэлцэл нь тааламжтай эсвэл тааламжгүй нөхцлөөр мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг хүлээн авах буюу өгөх, эсвэл санхүүгийн хөрөнгүүдийг солилцох гэрээний эрх, үүргийг үүсгэдэг байх.

ДҮ19. Арилжааны бус орлогын ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгө нь эдгээр шаардлагуудыг хангана гэж УСНББОУС3 дүгнэсэн. Тухайлбал; хандивлагчтай байгуулсан хэлцэл нь мөн чанарын хувьд гэрээ бөгөөд хандивлагчаас мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг уг хүлээн авагчид шилжүүлснээр барагдаж болох юм гэдгийг УСНББОУС3 тэмдэглэсэн. Энэ тохиолдолд арилжааны бус орлогын ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгө нь санхүүгийн хөрөнгө болно.

ДҮ20. Арилжааны бус орлогын ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгийн хувьд байгууллага нь УСНББОУС 28-ын хамтаар УСНББОУС 23-ын шаардлагуудыг даган мөрдөх хэрэгтэй гэдгийг УСНББОУС3 зөвшөөрсөн. Тухайлбал; арилжааны бус орлогын ажил гүйлгээнээс үүссэн нөөцийн орлогын гүйлгээ нь өр төлбөр бий болгох, эсвэл уг байгууллагын цэвэр хөрөнгө дэх үлдэх хувь оролцоог илэрхийлэх ажил гүйлгээ, өөрөөр хэлбэл өмчийн хэрэглүүр болох эсэхийг тогтоохдоо тухайн байгууллага нь УСНББОУС 28-ын зарчмуудыг харгалзан үзнэ.

ДҮ21. Арилжааны бус орлогын ажил гүйлгээнээс үүссэн өр төлбөр нь санхүүгийн өр төлбөр мөн эсэхийг УСНББОУС3 авч үзсэн. Байгууллага нь тусгай

нөхцөлд захирагдах нөөцийн орлогын гүйлгээг хүлээн авсан тохиолдолд УСНББОУС 23-ын дагуу өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Шилжүүлэгч нь нөөцийн шилжүүлгийн талаархи нөхцлүүдийг тухайн байгууллагад хүлээлгэдэг бөгөөд уг нөөцийг тодорхой арга замаар ашиглах, ихэвчлэн бараа, үйлчилгээг гуравдагч талд нийлүүлэхийн тулд ашиглах эсвэл тэрхүү шилжүүлэгчид буцаан өгөхийг шаарддаг. Энэ нь хэлцлийн нөхцлийг биелүүлэх үүрэг үүсгэдэг. Анх хүлээн зөвшөөрөх үед байгууллага нь тухайн нөөцийг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд энэ нь тодорхой нөхцөлд захирагддаг тохиолдолд холбогдох өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

ДҮ22. Уг анх хүлээн зөвшөөрсөн өр төлбөр нь мөн чанарын хувьд санхүүгийн өр төлбөр эсвэл нөөц гэх мэт бусад өр төлбөр эсэхийг УСНББОУС3 авч үзсэн. Байгууллагын үүрэг нь нөөцийг зориулалтын дагуу ашиглах, ихэвчлэн тодорхой цаг хугацаанд гуравдагч талд бараа, үйлчилгээ нийлүүлэхэд ашиглах тухайн гэрээний нөхцөл, болзлыг биелүүлэх явдал байдаг учраас хөрөнгийг хүлээн зөвшөөрөх үед өр төлбөр нь үндсэндээ санхүүгийн өр төлбөр биш гэдгийг УСНББОУС3 хүлээн зөвшөөрсөн. Харин анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа байгууллага нь хэлцлийн нөхцлүүдийг биелүүлж чадахгүй бөгөөд нөөцийг тухайн шилжүүлэгчид буцаан өгөх шаардлагатай бол байгууллага нь ДҮ18-р параграфт заасан шаардлагууд болон санхүүгийн хэрэглүүр ба санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг авч үзсэнээр уг өр төлбөр нь санхүүгийн өр төлбөр эсэхийг энэхүү үе шатанд үнэлнэ. Цөөн зарим тохиолдолд санхүүгийн өр төлбөр нь арилжааны бус орлогын ажил гүйлгээний нэг хэсэг болох нөөцийн шилжүүлтэнд тавигдах нөхцлөөс үүсэж болох юм. УСНББОУС3 нь энэхүү хувилбарыг ирээдүйн төслийн нэг хэсэг байдлаар авч үзэж болох юм.

ДҮ23. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа арилжааны бус орлогын ажил гүйлгээнээс бусад өр төлбөр үүсэж болно гэдгийг УСНББОУС3 бас тэмдэглэсэн. Жишээлбэл; байгууллага нь ирээдүйн үйл явдал зөвхөн гарч тохиолдох буюу эс тохиолдсоны дараа тухайн нөөцийг буцаахыг шаарддаг хэлцлийн дагуу нөөцийг хүлээн авч болох юм. ДҮ18-р параграфын шаардлагууд биелэгдсэн, санхүүгийн хэрэглүүр ба санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолт хангагдсан эсэхийг авч үзсэнээр байгууллага нь арилжааны бус орлогын ажил гүйлгээнээс үүссэн бусад өр төлбөр нь санхүүгийн өр төлбөр эсэхийг үнэлдэг.

## **Бусад**

*Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Тайлбарын Хорооны боловсруулсан тайлбарууд*

ДҮ24. Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Тайлбарын Хорооны Тайлбар (СТОУТХ) 2, *Хоршоон дахь Гишүүдийн Хувь Оролцоо ба Адилтгах Хэрэглүүрүүд* болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Тайлбарын Хорооны Тайлбар (СТОУТХ) 11, *СТОУС 2-Групп ба Халаасны Хувьцааны Ажил Гүйлгээ* нь засгийн газар ба улсын секторын байгууллагуудын



хооронд хийгдсэн хэрэглүүрийн төрлүүдэд хамааралтай эсэхийг УСНББОУСЗ авч үзсэн.

- ДҮ25. СТОУТХ 11 нь хувьцаанд суурилсан төлбөрийн ажил гүйлгээг авч үздэг тул улсын секторт хийгдсэн хэрэглүүрийн төрлүүдэд хамааралгүй гэж УСНББОУСЗ нь энэ Стандартыг гаргах үедээ дүгнэсэн. Хувьцаанд суурилсан төлбөр нь [Улсын Үйлдвэрийн Газруудад (УҮГ)] (2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргаснаас хойш ийм дөрвөлжин хаалтанд тусгасан нэр томъёог цаашид ашиглахаа больсон) нийтлэг байж болох боловч ийм ажил гүйлгээ нь УҮГ биш тийм байгууллагуудад байнга гарч тохиолдоод байдаггүй. Иймээс УСНББОУСЗ нь СТОУТХ 11-ээс ямар нэг зарчмыг УСНББОУС 28-д тусган оруулаагүй.
- ДҮ26. СТОУТХ 2 нь хоршооны гишүүдийн хувь оролцоо болон адилтгах хэрэглүүрүүдэд НББОУС 32-ыг мөрдөх талаархи заавар удирдамжаар хангадаг. Буцаах эрхтэй санхүүгийн хэрэглүүр ба татан буулгалтаас үүссэн үүргийн хувьд НББОУС 32 болон СТОУТХ 2-ын хооронд нягт уялдаа холбоо байдаг. Буцаах эрхтэй санхүүгийн хэрэглүүр ба татан буулгалтаас үүссэн үүргийн талаархи НББОУС 32-ын текстийг УСНББОУС 28-д тэр хэвээр оруулсан тул УСНББОУС 28-ын хэрэглэгчид нь хоршоон дахь гишүүдийн хувь оролцоонд эдгээр зарчмуудыг мөрдөх талаархи нэмэлт заавар удирдамжийг СТОУТХ 2-д тусгасан байдаг. Иймээс СТОУТХ 2-ын зарчим ба жишээнүүдийг УСНББОУС 28-д эрх бүхий хавсралт байдлаар тусган оруулсан.

**2012 оны 5 дугаар сард гаргасан, НББОУСЗ-ийн СТОУС-ын Сайжруулалтууд-ын үр дүнд УСНББОУС 28-д хийсэн хянан засварлалт**

- ДҮ27. УСНББОУСЗ нь 2012 оны 5 дугаар сард НББОУСЗ-өөс гаргасан *СТОУС-ын Сайжруулалтууд*-д тусгасан, НББОУС 32-ын хянан засварлалтыг нягталж шалгаад тэдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдөхгүй байх улсын секторын тусгай учир шалтгаан байхгүй гэдэгтэй ерөнхийдөө санал нийлсэн.

**2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУСЗ-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 28-д хийсэн хянан засварлалт**

- ДҮ28. УСНББОУСЗ нь 2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт нэмэлт өөрчлөлт оруулсан:
- (а) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
  - (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОЛИЛУУЛГА

- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р* параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

## Үлгэрчилсэн жишээ

Энэхүү үлгэрчилсэн жишээ нь УСНББОУС 28-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

### Байгууллагын өмчийн хэрэглүүрийн гэрээний тайлагнал

ҮЖ1. Байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрийн гэрээний тайлагналд УСНББОУС 28-ын 13-32-р параграфуудыг хэрхэн мөрдөхийг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан. Эдгээр жишээнд мөнгөн дүнг “тооцооны нэгж” (ТН) гэж тэмдэглэсэн.

#### Жишээ 1: Хувьцаа худалдан авах форвард гэрээ

ҮЖ2. Энэ жишээ нь (а) цэвэр мөнгөөр, (б) цэвэр хувьцаагаар, эсвэл (в) хувьцааны хариуд мөнгө өгснөөр барагдуулах тухайн байгууллагын өөрийн хувьцааны форвард худалдан авалтын гэрээний хувьд журналын бичилтүүдийг үлгэрчлэн харуулна. Мөн барагдуулах сонголтуудын үр нөлөөг авч хэлэлцсэн (доорх (г) заалтыг үзнэ үү). Үлгэрчилсэн жишээг хялбарчлах үүднээс форвард гэрээний бодит үнэ цэнэ нь тэгтэй тэнцүү үед уг форвард гэрээний үнийн өнөөгийн үнэ цэнэ нь спот үнэтэй тэнцүү байхын тулд тухайн суурь хувьцаанд ногдол ашиг төлөөгүй (өөрөөр хэлбэл, “хувьцааны эзэмшилтийн өгөөж” тэг) гэж үзсэн. Хувьцааны зах зээлийн үнэ ба тогтмол үнэтэй форвард гэрээний өнөөгийн үнэ цэнийн хоорондох зөрүүгээр уг форвард гэрээний бодит үнэ цэнийг тооцоолно.

#### Таамаглал:

Гэрээний огноо:	20X2 оны 02-р сарын 01
Дуусгавар болох огноо:	20X3 оны 01-р сарын 31
Нэгж хувьцааны зах зээлийн үнэ, 20X2 оны 02-р сарын 01	100ТН
Нэгж хувьцааны зах зээлийн үнэ, 20X2 оны 12-р сарын 31	110ТН
Нэгж хувьцааны зах зээлийн үнэ, 20X3 оны 01-р сарын 31	106ТН
20X3 оны 01-р сарын 31-нд төлөгдөх тогтмол форвард үнэ	104ТН
20X2 оны 02-р сарын 01 дэх форвард үнийн өнөөгийн үнэ цэнэ	100ТН
Форвард гэрээнд хамаарах хувьцааны тоо	1,000
Форвард гэрээний бодит үнэ цэнэ, 20X2 оны 02-р сарын 01	0ТН
Форвард гэрээний бодит үнэ цэнэ, 20X2 оны 12-р сарын 31	6,300ТН
Форвард гэрээний бодит үнэ цэнэ, 20X3 оны 01-р сарын 31	2,000ТН

**(а) Мөнгийг мөнгөөр (“Цэвэр мөнгөн барагдуулалт”)**

ҮЖЗ. Энэхүү дэд хэсэгт байгууллагын өөрийн хувьцааны форвард худалдан авалтын гэрээг цэвэр мөнгөөр барагдуулна. Өөрөөр хэлбэл, форвард гэрээг барагдуулахдаа тухайн байгууллагын өөрийн хувьцааг хүлээн авахгүй эсвэл өгөхгүй.

20X2 оны 02-р сарын 01-нд “А” байгууллага нь 20X3 оны 01-р сарын 31-нд 104,000ТН-ийн мөнгөн төлбөрийн хариуд эргэлтэнд байгаа өөрийн 1,000 ширхэг хувьцааны 20X3 оны 01-р сарын 31-ний өдрийн бодит үнэ цэнэ (өөрөөр хэлбэл, нэгж хувьцаанд 104ТН)-ийг хүлээн авах гэрээг “Б” байгууллагатай байгуулсан. Уг гэрээг цэвэр мөнгөөр төлж барагдуулна. “А” байгууллага нь дараах журналын бичилтийг хийнэ.

**20X2 оны 2-р сарын 01.**

20X2 оны 02-р сарын 01-нд гэрээг байгуулах үед нэгж хувьцааны үнэ нь 100ТН байсан. 20X2 оны 02-р сарын 01-нд форвард гэрээний анхны бодит үнэ цэнэ нь тэг байсан.

*Үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнэ нь тэг бөгөөд ямар нэг мөнгө төлөөгүй буюу хүлээн аваагүй тул журналын бичилт хийх шаардлагагүй.*

**20X2 оны 12-р сарын 31.**

20X2 оны 12-р сарын 31-нд нэгж хувьцааны зах зээлийн үнэ нь 110ТН болж өссөний үр дүнд форвард гэрээний бодит үнэ цэнэ нь 6,300ТН болж өссөн.

Дебит	Форвард хөрөнгө	6,300ТН	
	Кредит Олз		6,300ТН

*Форвард гэрээний бодит үнэ цэнийн өсөлтийг бүртгэх.*

**20X3 оны 01-р сарын 31.**

20X3 оны 01-р сарын 31-нд нэгж хувьцааны зах зээлийн үнэ нь 106ТН болж буурсан. Форвард гэрээний бодит үнэ цэнэ нь 2,000ТН ([106ТН x1,000] - 104,000ТН) болно.

Мөн энэ өдөр гэрээг цэвэр мөнгөөр төлж барагдуулсан. “А” байгууллага нь 104,000ТН-ийг “Б” байгууллагад өгөх, харин “Б” байгууллага нь 106,000ТН (106ТН x1,000)-ийг “А” байгууллагад өгөх үүрэг хүлээсэн, иймээс “Б” байгууллага нь цэвэр дүнгээр 2,000ТН-ийг “А” байгууллагад төлнө.

Дебит	Гарз	4,300ТН	
	Кредит Форвард хөрөнгө		4,300ТН

*Форвард гэрээний бодит үнэ цэнийн бууралтыг (өөрөөр хэлбэл, 4,300ТН=6,300ТН-2,000ТН) бүртгэх.*

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОЛИЛУУЛГА

Дебит	Мөнгө	2,000ТН	
	Кредит	Форвард хөрөнгө	2,000ТН

*Форвард гэрээний барагдуулалтыг бүртгэх.*

**(б) Хувьцааг хувьцаагаар (“Цэвэр хувьцаагаар барагдуулалт”)**

- ҮЖ4. Төлбөрийг цэвэр мөнгөөр хийнэ гэдгийн оронд цэвэр хувьцаагаар барагдуулахаас бусад нөхцөл нь дээрх (а)-д дурдсантай ижил гэж үзье. “А” байгууллагын хийх журналын бичилтүүд нь форвард гэрээний барагдуулалтыг бүртгэхээс бусад тохиолдолд дээрх (а)-д харуулсан журналын бичилттэй ижил байна.

**20Х3 оны 01-р сарын 31.**

Гэрээг цэвэр хувьцаагаар төлж барагдуулсан. “А” байгууллага нь 104,000ТН (104ТН х1,000)-ийн үнэ цэнэтэй өөрийн хувьцааг “Б” байгууллагад өгөх, “Б” байгууллага нь 106,000ТН (106ТН х1,000)-ийн үнэ цэнэтэй түүний хувьцааг “А” байгууллагад өгөх үүрэгтэй. Иймээс “Б” байгууллага нь цэвэр дүнгээр 2,000ТН (106,000ТН - 104,000ТН)-ийн үнэ цэнэтэй хувьцааг, өөрөөр хэлбэл 18.9 ширхэг (2,000ТН/106ТН) хувьцааг “А” байгууллагад өгнө.

Дебит	Цэвэр хөрөнгө/өмч	2,000ТН	
	Кредит	Форвард хөрөнгө	2,000ТН

*Форвард гэрээний барагдуулалтыг бүртгэх.*

**(в) Хувьцааг мөнгөөр (“Нийт биет барагдуулалт”)**

- ҮЖ5. Төлбөрийг тогтмол дүн бүхий мөнгө өгөх ба “А” байгууллагын тогтмол тооны хувьцааг авснаар барагдуулахаас бусад нөхцөл нь дээрх (а)-д дурдсантай ижил гэж үзье. Дээрх (а) ба (б)-д дурдсантай адилаар, нэг жилийн дараа “А” байгууллагын төлөх нэгж хувьцааны үнэ нь тогтмол 104ТН байна. Иймээс нэг жилийн дараа “А” байгууллага нь 104,000ТН (104ТНх1,000)-ийн мөнгийг “Б” байгууллагад төлөх, харин “Б” байгууллага нь “А” байгууллагын эргэлтэнд буй 1,000 ширхэг хувьцааг “А” байгууллагад өгөх үүрэгтэй. Иймээс “А” байгууллага нь дараах журналын бичилт хийнэ:

**20Х2 оны 02-р сарын 01.**

Дебит	Цэвэр хөрөнгө/өмч	100,000ТН	
	Кредит	Өр төлбөр	100,000ТН

*Нэг жилийн дараа төлөх 104,000ТН-ийн зохих хүүний түвшинг ашиглан дискаунтчилсан 100,000ТН-ийн өнөөгийн үнэ цэнээр бүртгэх (УСНББОУС 29-ийн МЗУ82-р параграфыг үзнэ үү).*

**20Х2 оны 12-р сарын 31.**

Дебит	Хүүний зардал	3,660ТН	
	Кредит	Өр төлбөр	3,660ТН

*Хувьцааг эргэлтээс гаргах өр төлбөрийн хувьд үр ашигтай хүүний аргын дагуу хүүг хуримтлуулан бүртгэх.*

**20Х3 оны 01-р сарын 31.**

Дебит	Хүүний зардал	340ТН	
	Кредит	Өр төлбөр	340ТН

*Хувьцааг эргэлтээс гаргах өр төлбөрийн хувьд үр ашигтай хүүний аргын дагуу хүүг хуримтлуулан бүртгэх.*

“А” байгууллага нь 104,000ТН-ийн мөнгийг “Б” байгууллагад төлсөн, харин “Б” байгууллага нь “А” байгууллагын 1,000 ширхэг хувьцааг “А” байгууллагад өгсөн.

Дебит	Өр төлбөр	104,000ТН	
	Кредит	Мөнгө	104,000ТН

*“А” байгууллагын өөрийн хувьцааг мөнгөөр эргэлтээс гаргах уг өр төлбөрийн барагдуулалтыг бүртгэх.*

**(г) Барагдуулалтын сонголтууд**

ҮЖ6. Төлбөр барагдуулах сонголтуудтай (цэвэр мөнгөөр, цэвэр хувьцаагаар, мөнгө ба хувьцааны солилцоогоор гэх мэт) байх нь уг форвард буцаан худалдан авалтын гэрээг санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөр болгоход хүргэдэг. Төлбөр барагдуулах хувилбаруудын нэг нь хувьцааг мөнгөөр солилцох (дээрх (в) гэх мэт) явдал бол “А” байгууллага нь дээрх (в)-д харуулсанчлан, мөнгө өгөх үүргийн хувьд өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Үүнээс бусад тохиолдолд “А” байгууллага нь форвард гэрээг үүсмэл хэрэглүүр гэж тайлагнана.

**Жишээ 2: Хувьцааг борлуулах форвард гэрээ**

ҮЖ7. Энэ жишээ нь (а) цэвэр мөнгөөр, (б) цэвэр хувьцаагаар, эсвэл (в) хувьцааны хариуд мөнгө өгснөөр барагдуулах тухайн байгууллагын өөрийн хувьцааны форвард борлуулалтын гэрээний хувьд журналын бичилтүүдийг үлгэрчлэн харуулна. Мөн барагдуулах сонголтуудын үр нөлөөг авч хэлэлцсэн (доорх (г) заалтыг үзнэ үү). Үлгэрчилсэн жишээг хялбарчлах үүднээс форвард гэрээний бодит үнэ цэнэ нь тэгтэй тэнцүү үед уг форвард гэрээний үнийн өнөөгийн үнэ цэнэ нь спот үнэтэй тэнцүү байхын тулд тухайн суурь хувьцаанд ногдол ашиг төлөөгүй (өөрөөр хэлбэл, “хувьцааны эзэмшилтийн өгөөж” тэг) гэж үзсэн. Хувьцааны зах зээлийн үнэ ба тогтмол үнэтэй форвард гэрээний өнөөгийн үнэ цэнийн хоорондох зөрүүгээр уг форвард гэрээний бодит үнэ цэнийг тооцоолно.

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОЛИЛУУЛГА

**Таамаглал:**

Гэрээний огноо: 20X2 оны 02-р сарын 01  
 Дуусгавар болох огноо: 20X3 оны 01-р сарын 31

Нэгж хувьцааны зах зээлийн үнэ, 20X2 оны 02-р сарын 01	100ТН
Нэгж хувьцааны зах зээлийн үнэ, 20X2 оны 12-р сарын 31	110ТН
Нэгж хувьцааны зах зээлийн үнэ, 20X3 оны 01-р сарын 31	106ТН
20X3 оны 01-р сарын 31-нд төлөгдөх тогтмол форвард үнэ	104ТН
20X2 оны 02-р сарын 01 дэх форвард үнийн өнөөгийн үнэ цэнэ	100ТН
Форвард гэрээнд хамаарах хувьцааны тоо	1,000
Форвард гэрээний бодит үнэ цэнэ, 20X2 оны 02-р сарын 01	0ТН
Форвард гэрээний бодит үнэ цэнэ, 20X2 оны 12-р сарын 31	(6,300ТН)
Форвард гэрээний бодит үнэ цэнэ, 20X3 оны 01-р сарын 31	(2,000ТН)

**(а) Мөнгийг мөнгөөр (“Цэвэр мөнгөн барагдуулалт”)**

ҮЖ8. 20X2 оны 02-р сарын 01-нд “А” байгууллага нь 20X3 оны 01-р сарын 31-нд 104,000ТН-ийн мөнгөний хариуд эргэлтэнд байгаа өөрийн 1,000 ширхэг хувьцааны 20X3 оны 01-р сарын 31-ний өдрийн бодит үнэ цэнэ (өөрөөр хэлбэл, нэгж хувьцаанд 104ТН)-ийг төлөх гэрээг “Б” байгууллагатай байгуулсан. Уг гэрээг цэвэр мөнгөөр төлж барагдуулна. “А” байгууллага нь дараах журналын бичилтийг хийнэ.

**20X2 оны 2-р сарын 01.**

*Үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнэ нь тэг бөгөөд ямар нэг мөнгө төлөөгүй буюу хүлээн аваагүй тул журналын бичилт хийх шаардлагагүй.*

**20X2 оны 12-р сарын 31.**

Дебит	Гарз	6,300ТН	
	Кредит	Форвард өр төлбөр	6,300ТН

*Форвард гэрээний бодит үнэ цэнийн бууралтыг бүртгэх.*

**20Х3 оны 01-р сарын 31.**

Дебит	Форвард өр төлбөр	4,300ТН	
	Кредит Олз		4,300ТН

*Форвард гэрээний бодит үнэ цэнийн өсөлтийг (өөрөөр хэлбэл, 4,300ТН=6,300ТН-2,000ТН) бүртгэх.*

Гэрээг цэвэр мөнгөөр төлж барагдуулсан. “Б” байгууллага нь 104,000ТН-ийг “А” байгууллагад өгөх, харин “А” байгууллага нь 106,000ТН (106ТН х1,000)-ийг “Б” байгууллагад өгөх үүрэг хүлээсэн. Иймээс “А” байгууллага нь цэвэр дүнгээр 2,000ТН-ийг “Б” байгууллагад төлнө.

Дебит	Форвард өр төлбөр	2,000ТН	
	Кредит Мөнгө		2,000ТН

*Форвард гэрээний барагдуулалтыг бүртгэх.*

**(б) Хувьцааг хувьцаагаар (“Цэвэр хувьцаагаарх барагдуулалт”)**

ҮЖ9. Төлбөрийг цэвэр мөнгөөр хийнэ гэдгийн оронд цэвэр хувьцаагаар барагдуулахаас бусад нөхцөл нь дээрх (а)-д дурдсантай ижил гэж үзье. “А” байгууллагын хийх журналын бичилтүүд нь доор дурдсанаас бусад тохиолдолд дээрх (а)-д харуулсан журналын бичилттэй ижил байна.

**20Х3 оны 01-р сарын 31.**

Гэрээг цэвэр хувьцаагаар төлж барагдуулсан. “А” байгууллага нь 104,000ТН (104ТН х1,000)-ийн үнэ цэнэтэй өөрийн хувьцааг “Б” байгууллагаас авах эрхтэй ба 106,000ТН (106ТН х1,000)-ийн үнэ цэнэтэй өөрийн хувьцааг “Б” байгууллагад өгөх үүрэгтэй. Иймээс “А” байгууллага нь цэвэр дүнгээр 2,000ТН (106,000ТН - 104,000ТН)-ийн үнэ цэнэтэй хувьцааг, өөрөөр хэлбэл 18.9 ширхэг (2,000ТН/106ТН) хувьцааг “Б” байгууллагад өгнө.

Дебит	Форвард өр төлбөр	2,000ТН	
	Кредит Цэвэр хөрөнгө/өмч		2,000ТН

*Форвард гэрээний барагдуулалтыг бүртгэх. Байгууллагын өөрийн хувьцааны гаргалтыг цэвэр хөрөнгө/өмчийн ажил гүйлгээ гэж үзнэ.*

**(в) Мөнгийг хувьцаагаар (“Нийт биет барагдуулалт”)**

ҮЖ10. Төлбөрийг тогтмол дүн бүхий мөнгө авах ба тухайн байгууллагын тогтмол тооны хувьцааг өгснөөр барагдуулахаас бусад нөхцөл нь дээрх (а)-д дурдсантай ижил гэж үзье. Дээрх (а) ба (б)-д дурдсантай адилаар, нэг жилийн дараа “А” байгууллагын төлөх нэгж хувьцааны үнэ нь тогтмол 104ТН байна. Иймээс нэг жилийн дараа “А” байгууллага нь 104,000ТН (104ТН х1,000)-ийн мөнгийг авах эрхтэй ба өөрийн 1,000 ширхэг хувьцааг өгөх үүрэгтэй. Иймээс “А” байгууллага нь дараах журналын бичилт хийнэ:



**20Х2 оны 2-р сарын 01.**

02-р сарын 01-нд ямар нэг бичилт хийхгүй. Форвард гэрээ нь тэг (0) анхны бодит үнэ цэнэтэй учраас ямар нэг мөнгө төлөхгүй эсвэл хүлээн авахгүй. Тогтмол дүн бүхий мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийн хариуд “А” байгууллагын тогтмол тооны өөрийн хувьцааг өгөх форвард гэрээ нь уг мөнгөний хариуд хувьцаа өгөхөөс өөр бусад байдлаар барагдуулагдах боломжгүй учраас өмчийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангана.

**20Х2 оны 12-р сарын 31.**

Ямар нэг мөнгө төлөхгүй эсвэл хүлээн авахгүй бөгөөд тогтмол дүн бүхий мөнгөний хариуд “А” байгууллагын тогтмол тооны өөрийн хувьцааг өгөх форвард гэрээ нь тухайн байгууллагын өмчийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангах учраас 12-р сарын 31-нд бичилт хийхгүй.

**20Х3 оны 01-р сарын 31.**

20Х3 оны 01-р сарын 31-нд “А” байгууллага нь 104,000ТН-ийн мөнгийг хүлээн авч, 1,000 ширхэг хувьцааг өгсөн.

Дебит	Мөнгө	104,000ТН	
	Кредит	Цэвэр хөрөнгө/өмч	104,000ТН

Форвард гэрээний барагдуулалтыг бүртгэх.

**(г) Барагдуулалтын сонголтууд**

ҮЖ11. Төлбөр барагдуулах сонголтуудтай (цэвэр мөнгөөр, цэвэр хувьцаагаар, мөнгө ба хувьцааны солилцоогоор гэх мэт) байх нь уг форвард гэрээг санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөр болгоход хүргэдэг. “А” байгууллага нь тогтмол дүн бүхий мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг төлсний хариуд өөрийн тогтмол тооны хувьцааг буцаан худалдан авахаас өөр бусад байдлаар барагдуулж болох учраас энэ нь өмчийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангахгүй. “А” байгууллага нь үүсмэл хөрөнгө буюу өр төлбөрийг дээрх (а) ба (б)-д үлгэрчлэн харуулсантай адилаар хүлээн зөвшөөрнө. Төлбөр барагдуулалтаар хийх нягтлан бодох бүртгэлийн бичилт нь уг гэрээг бодитойгоор хэрхэн барагдуулснаас хамаардаг.

*Жишээ 3: Хувьцааны, худалдан авсан дуудах опцион*

ҮЖ12. Энэ жишээ нь (а) цэвэр мөнгөөр, (б) цэвэр хувьцаагаар, эсвэл (в) тухайн байгууллагын хувьцааны хариуд мөнгө өгснөөр барагдуулах уг байгууллагын өөрийн хувьцааны хувьд худалдан авсан, дуудах опционы эрхийн журналын бичилтүүдийг үлгэрчлэн харуулна. Мөн барагдуулах сонголтуудын үр нөлөөг авч хэлэлцсэн (доорх (г) заалтыг үзнэ үү).

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОЛИЛУУЛГА

**Таамаглал:**

Гэрээний огноо: 20X2 оны 02-р сарын 01  
 Хэрэгжүүлэх огноо: 20X3 оны 01-р сарын 31  
 (Европын нэр томъёо, өөрөөр хэлбэл, үүнийг зөвхөн дуусгавар болох үед хэрэгжүүлнэ)

Хэрэгжүүлэх эрхийн эзэмшигч Тайлагнагч байгууллага  
 (“А” байгууллага)

Нэгж хувьцааны зах зээлийн үнэ, 20X2 оны 02-р сарын 01	100ТН
Нэгж хувьцааны зах зээлийн үнэ, 20X2 оны 12-р сарын 31	104ТН
Нэгж хувьцааны зах зээлийн үнэ, 20X3 оны 01-р сарын 31	104ТН
20X3 оны 01-р сарын 31-нд төлөгдөх тогтмол хэрэгжүүлэх үнэ	102ТН
Опционы гэрээнд хамаарах хувьцааны тоо	1,000
Опционы бодит үнэ цэнэ, 20X2 оны 02-р сарын 01	5,000ТН
Опционы бодит үнэ цэнэ, 20X2 оны 12-р сарын 31	3,000ТН
Опционы бодит үнэ цэнэ, 20X3 оны 01-р сарын 31	2,000ТН

**(а) Мөнгийг мөнгөөр (“Цэвэр мөнгөн барагдуулалт”)**

ҮЖ13. 20X2 оны 02-р сарын 01-нд “А” байгууллага нь “Б” байгууллагатай гэрээ байгуулсан бөгөөд уг гэрээний дагуу 20X3 оны 01-р сарын 31-нд “А” байгууллага нь эрхийг хэрэгжүүлвэл “Б” байгууллага нь 102,000ТН (өөрөөр хэлбэл, нэгж хувьцаанд 102ТН)-ийн мөнгөний хариуд “А” байгууллагын 1,000 ширхэг энгийн хувьцааны 20X3 оны 01-р сарын 31-ний өдрөөрх бодит үнэ цэнийг төлөх үүрэг хүлээх ба “А” байгууллага нь уг өөрийн хувьцааны бодит үнэ цэнийг авах эрхтэй болно. Гэрээг цэвэр мөнгөөр төлж барагдуулна. Хэрэв “А” байгууллага нь өөрийн эрхийг хэрэгжүүлэхгүй бол ямар нэг төлбөр хийгдэхгүй. “А” байгууллага нь дараах журналын бичилт хийнэ.

**20X2 оны 02-сарын 01.**

20X2 оны 02-р сарын 01-нд гэрээг байгуулах үед нэгж хувьцааны үнэ нь 100ТН байсан. 20X2 оны 02-р сарын 01-нд опционы гэрээний анхны бодит үнэ цэнэ нь 5,000ТН байсан бөгөөд “А” байгууллага нь тухайн өдөр энэ дүнг “Б” байгууллагад төлөх юм. Опционы 102ТН-ийн хэрэгжүүлэх үнэ нь нэгж хувьцааны 100ТН-ийн зах зээлийн үнээс илүү бөгөөд иймээс “А” байгууллага опционыг хэрэгжүүлэх нь үр ашиггүй тул опцион нь тухайн өдөр дотоод үнэ

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОЛИЛУУЛГА

цэнэгүй, зөвхөн цаг хугацааны үнэ цэнэтэй байна. Өөрөөр хэлбэл, дуудах опцион нь мөнгөн алдагдалтай байна.

Дебит	Дуудах опционы хөрөнгө	5,000ТН	
	Кредит Мөнгө		5,000ТН

*Худалдан авсан дуудах опционыг хүлээн зөвшөөрөх.*

**20Х2 оны 12-р сарын 31.**

20Х2 оны 12-р сарын 31-нд нэгж хувьцааны зах зээлийн үнэ нь 104ТН болж өссөн. Дуудах опционы бодит үнэ цэнэ нь 3,000ТН болж буурсан бөгөөд үүний 2,000ТН ( $(104ТН - 102ТН) \times 1,000$ ) нь дотоод үнэ цэнэ, 1,000ТН нь үлдэж буй цаг хугацааны үнэ цэнэ байв.

Дебит	Гарз	2,000ТН	
	Кредит Дуудах опционы хөрөнгө		2,000ТН

*Дуудах опционы бодит үнэ цэнийн бууралтыг бүртгэх.*

**20Х3 оны 01-р сарын 31.**

20Х3 оны 01-р сарын 31-нд нэгж хувьцааны зах зээлийн үнэ нь 104ТН хэвээр байсан. Дуудах опционы бодит үнэ цэнэ нь 2,000ТН болж буурсан бөгөөд цаг хугацааны үнэ цэнэ үлдээгүй тул энэ үнэ нь бүгдээрээ ( $(104ТН - 102ТН) \times 1,000$ ) дотоод үнэ цэнэ болно.

Дебит	Гарз	1,000ТН	
	Кредит Дуудах опционы хөрөнгө		1,000ТН

*Дуудах опционы бодит үнэ цэнийн бууралтыг бүртгэх.*

Мөн энэ өдөр “А” байгууллага нь дуудах опционоо хэрэгжүүлсэн бөгөөд уг гэрээг цэвэр мөнгөөр барагдуулсан. “Б” байгууллага нь “А” байгууллагаас 102,000ТН ( $102ТН \times 1,000$ )-ийг авсаны хариуд “А” байгууллагад 104,000ТН ( $104ТН \times 1,000$ )-ийг өгөх үүрэгтэй тул “А” байгууллага нь 2,000ТН-ийн цэвэр дүнг хүлээн авсан.

Дебит	Мөнгө	2,000ТН	
	Кредит Дуудах опционы хөрөнгө		2,000ТН

*Опционы гэрээний барагдуулалтыг бүртгэх.*

**(б) Хувьцааг хувьцаагаар (“Цэвэр хувьцаагаар барагдуулалт”)**

ҮЖ14. Төлбөрийг цэвэр мөнгөөр хийнэ гэдгийн оронд цэвэр хувьцаагаар барагдуулахаас бусад нөхцөл нь дээрх (а)-д дурдсантай ижил гэж үзье. Опционы гэрээний барагдуулалтыг дараах байдлаар бүртгэхээс бусад тохиолдолд “А” байгууллагын хийх журналын бичилтүүд нь дээрх (а)-д харуулсан журналын бичилттэй ижил байна.

**20X3 оны 01-р сарын 31.**

“А” байгууллага нь дуудах опционоо хэрэгжүүлсэн бөгөөд уг гэрээг цэвэр хувьцаагаар барагдуулсан. “Б” байгууллага нь “А” байгууллагын 102,000ТН (102ТНх1,000)-ийн үнэ цэнэтэй хувьцааг авсаны хариуд түүнд 104,000ТН (104ТНх1,000)-ийн үнэ цэнэтэй “А” байгууллагын хувьцааг өгөх үүрэгтэй. Иймээс “Б” байгууллага нь цэвэр дүнгээр 2,000ТН-ийн үнэ цэнэтэй хувьцааг, өөрөөр хэлбэл 19.2 ширхэг (2,000ТН/104ТН) хувьцааг “А” байгууллагад өгнө.

Дебит	Цэвэр хөрөнгө/өмч	2,000ТН	
	Кредит Дуудах опционы хөрөнгө		2,000ТН

*Опционы гэрээний барагдуулалтыг бүртгэх. Уг барагдуулалтыг халаасны хувьцааны ажил гүйлгээтэй адилаар (өөрөөр хэлбэл, олз буюу гарз байхгүй) тайлагнана.*

**(в) Хувьцааг мөнгөөр (“Нийт биет барагдуулалт”)**

- ҮЖ15. Хэрэв “А” байгууллага нь опционыг хэрэгжүүлвэл тогтмол дүн бүхий мөнгө төлөх ба тогтмол тооны хувьцааг авснаар төлбөрийг барагдуулахаас бусад нөхцөл нь дээрх (а)-д дурдсантай ижил гэж үзье. Дээрх (а) ба (б)-д дурдсантай адилаар, нэгж хувьцааны хэрэгжүүлэлтийн үнэ нь тогтмол 102ТН байна. Иймээс “А” байгууллага нь опционоо хэрэгжүүлвэл 102,000ТН (102ТНх1,000)-ийн мөнгөний хариуд эргэлтэнд буй өөрийн 1,000 ширхэг хувьцааг хүлээн авах эрхтэй болно. Иймээс “А” байгууллага нь дараах журналын бичилт хийнэ:

**20X2 оны 02-р сарын 01.**

Дебит	Цэвэр хөрөнгө/өмч	5,000ТН	
	Кредит Мөнгө		5,000ТН

*Нэг жилийн дараа “А” байгууллага өөрийн хувьцааг тогтмол үнээр хүлээн авах эрхийн хариуд төлсөн мөнгийг бүртгэх. Төлсөн урамшууллыг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө.*

**20X2 оны 12-р сарын 31.**

*Ямар нэг мөнгө хүлээн авахгүй буюу төлөхгүй бөгөөд тогтмол дүн бүхий мөнгөний хариуд “А” байгууллагын тогтмол тооны өөрийн хувьцааг хүлээн авах эрхийг олгодог гэрээ нь тухайн байгууллагын өмчийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангах учраас 12 дугаар сарын 31-нд бичилт хийхгүй.*

**20X3 оны 01-р сарын 31.**

“А” байгууллага нь дуудах опционоо хэрэгжүүлсэн бөгөөд уг гэрээг нийт дүнгээр барагдуулсан. “Б” байгууллага нь 102,000ТН-ийн мөнгөний хариуд “А” байгууллагын 1,000 ширхэг хувьцааг өгөх үүрэгтэй.

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОЛИЛУУЛГА

Дебит	Цэвэр хөрөнгө/өмч	102,000ТН	
Кредит	Мөнгө		102,000ТН

*Опционы гэрээний барагдуулалтыг бүртгэх.*

**(г) Барагдуулалтын сонголтууд**

ҮЖ16. Төлбөр барагдуулах сонголтуудтай (цэвэр мөнгөөр, цэвэр хувьцаагаар, мөнгө ба хувьцааны солилцоогоор гэх мэт) байх нь уг дуудах опционыг санхүүгийн хөрөнгө болгоход хүргэдэг. “А” байгууллага нь тогтмол дүн бүхий мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг төлсний хариуд өөрийн тогтмол тооны хувьцааг буцаан худалдан авахаас өөр бусад байдлаар барагдуулж болох учраас энэ нь өмчийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангахгүй. “А” байгууллага нь үүсмэл хөрөнгийг дээрх (а) ба (б)-д үлгэрчлэн харуулсантай адилаар хүлээн зөвшөөрнө. Төлбөр барагдуулалтаар хийх нягтлан бодох бүртгэлийн бичилт нь уг гэрээг бодитойгоор хэрхэн барагдуулснаас хамаардаг.

*Жишээ 4: Хувьцааны, гаргасан дуудах опцион*

ҮЖ17. Энэ жишээ нь (а) цэвэр мөнгөөр, (б) цэвэр хувьцаагаар, эсвэл (в) хувьцааны хариуд мөнгө өгснөөр барагдуулах уг байгууллагын өөрийн хувьцааны хувьд гаргасан дуудах опционы үүргийн журналын бичилтүүдийг үлгэрчлэн харуулна. Мөн барагдуулах сонголтуудын үр нөлөөг авч хэлэлцсэн (доорх (г) заалтыг үзнэ үү).

**Таамаглал:**

Гэрээний огноо:	20X2 оны 02-р сарын 01
Хэрэгжүүлэх огноо:	20X3 оны 01-р сарын 31

Хэрэгжүүлэх эрхийн эзэмшигч	Нөгөө байгууллага ("Б" байгууллага)
-----------------------------	--

Нэгж хувьцааны зах зээлийн үнэ, 20X2 оны 02-р сарын 01	100ТН
Нэгж хувьцааны зах зээлийн үнэ, 20X2 оны 12-р сарын 31	104ТН
Нэгж хувьцааны зах зээлийн үнэ, 20X3 оны 01-р сарын 31	104ТН
20X3 оны 01-р сарын 31-нд төлөгдөх тогтмол хэрэгжүүлэх үнэ	102ТН
Опционы гэрээнд хамаарах хувьцааны тоо	1,000
Опционы бодит үнэ цэнэ, 20X2 оны 02-р сарын 01	5,000ТН
Опционы бодит үнэ цэнэ, 20X2 оны 12-р сарын 31	3,000ТН
Опционы бодит үнэ цэнэ, 20X3 оны 01-р сарын 31	2,000ТН

**(а) Мөнгийг мөнгөөр (“Цэвэр мөнгөн барагдуулалт”)**

ҮЖ18. “А” байгууллага нь өөрийн хувьцааны хувьд худалдан авсан дуудах опционтой байна гэдгийн оронд гаргасан дуудах опционтой гэдгээс бусад нөхцөл нь дээрх Жишээ 3(а)-д дурдсантай ижил гэж үзье. Иймээс 20Х2 оны 02-р сарын 01-нд “А” байгууллага нь “Б” байгууллагатай гэрээ байгуулсан бөгөөд уг гэрээний дагуу 20Х3 оны 01-р сарын 31-нд “Б” байгууллага нь эрхийг хэрэгжүүлвэл “А” байгууллага нь 102,000ТН-ийн (өөрөөр хэлбэл, нэгж хувьцаа 102ТН) мөнгөний хариуд өөрийн 1,000 ширхэг энгийн хувьцааны 20Х3 оны 01-р сарын 31-ний бодит үнэ цэнийг төлөх үүрэгтэй ба “Б” байгууллага нь уг бодит үнэ цэнийг авах эрхтэй болсон. Гэрээг цэвэр мөнгөөр төлж барагдуулна. Хэрэв “Б” байгууллага нь өөрийн эрхийг хэрэгжүүлэхгүй бол ямар нэг төлбөр хийгдэхгүй. “А” байгууллага нь дараах журналын бичилт хийнэ.

**20Х2 оны 02-р сарын 01.**

Дебит	Мөнгө	5,000ТН	
	Кредит	Дуудах опционы өр төлбөр	5,000ТН

*Гаргасан дуудах опционыг хүлээн зөвшөөрөх.*

**20Х2 оны 12-р сарын 31.**

Дебит	Дуудах опционы өр төлбөр	2,000ТН	
	Кредит	Олз	2,000ТН

*Дуудах опционы бодит үнэ цэнийн бууралтыг бүртгэх.*

**20Х3 оны 01-р сарын 31.**

Дебит	Дуудах опционы өр төлбөр	1,000ТН	
	Кредит	Олз	1,000ТН

*Дуудах опционы бодит үнэ цэнийн бууралтыг бүртгэх.*

Мөн энэ өдөр “Б” байгууллага нь дуудах опционыг хэрэгжүүлсэн бөгөөд уг гэрээг цэвэр мөнгөөр барагдуулсан. “А” байгууллага нь “Б” байгууллагаас 102,000ТН (102ТН х1,000)-ийг авсаны хариуд “Б” байгууллагад 104,000ТН (104ТН х1,000)-ийг өгөх үүрэг хүлээсэн, иймээс “А” байгууллага нь цэвэр дүнгээр 2,000ТН-ийг төлнө.

Дебит	Дуудах опционы өр төлбөр	2,000ТН	
	Кредит	Мөнгө	2,000ТН

*Опционы гэрээний барагдуулалтыг бүртгэх.*

**(б) Хувьцааг хувьцаагаар (“Цэвэр хувьцаагаарх төлбөр”)**

ҮЖ19. Төлбөрийг цэвэр мөнгөөр хийнэ гэдгийн оронд цэвэр хувьцаагаар барагдуулахаас бусад нөхцөл нь дээрх (а)-д дурдсантай ижил гэж үзье. Опционы гэрээний барагдуулалтыг дараах байдлаар бүртгэхээс бусад тохиолдолд “А” байгууллагын хийх журналын бичилтүүд нь дээрх (а)-д харуулсан журналын бичилттэй ижил байна.

**20X3 оны 12-р сарын 31.**

“Б” байгууллага нь дуудах опционоо хэрэгжүүлсэн бөгөөд уг гэрээг цэвэр хувьцаагаар барагдуулсан. “А” байгууллага нь өөрийн 102,000ТН (102ТНх1,000)-ийн үнэ цэнэтэй хувьцааг авсаны хариуд “Б” байгууллагад мөн өөрийн 104,000ТН (104ТНх1,000)-ийн үнэ цэнэтэй хувьцааг өгөх үүрэгтэй. Иймээс “А” байгууллага нь цэвэр дүнгээр 2,000ТН-ийн үнэ цэнэтэй хувьцааг, өөрөөр хэлбэл 19.2 ширхэг (2,000ТН/104ТН) хувьцааг “Б” байгууллагад өгнө.

Дебит	Дуудах опционы хөрөнгө	2,000ТН	
	Кредит Цэвэр хөрөнгө/өмч		2,000ТН

*Опционы гэрээний барагдуулалтыг бүртгэх. Уг барагдуулалтыг цэвэр хөрөнгө/өмчийн ажил гүйлгээтэй адилаар тайлагнана.*

**(в) Хувьцааг мөнгөөр (“Нийт биет барагдуулалт”)**

ҮЖ20. Хэрэв “Б” байгууллага нь опционыг хэрэгжүүлвэл тогтмол дүн бүхий мөнгө хүлээн авах ба тогтмол тооны хувьцааг өгснөөр төлбөрийг барагдуулахаас бусад нөхцөл нь дээрх (а)-д дурдсантай ижил гэж үзье. Дээрх (а) ба (б)-д дурдсантай адилаар, нэгж хувьцааны хэрэгжүүлэлтийн үнэ нь тогтмол 102ТН байна. Иймээс “Б” байгууллага нь опционоо хэрэгжүүлвэл 102,000ТН (102ТН х1,000)-ийн мөнгөний хариуд “А” байгууллагын эргэлтэнд буй 1,000 ширхэг хувьцааг хүлээн авах эрхтэй болно. Иймээс “А” байгууллага нь дараах журналын бичилт хийнэ:

**20X2 оны 02-р сарын 01.**

Дебит	Мөнгө	5,000ТН	
	Кредит Цэвэр хөрөнгө/өмч		5,000ТН

*Нэг жилийн дараа “А” байгууллагын тогтмол тооны өөрийн хувьцааг тогтмол үнээр өгөх үүргийн хариуд хүлээн авсан мөнгийг бүртгэх. Хүлээн авсан урамшууллыг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө. Хэрэгжүүлснээр уг опцион нь тогтмол дүн бүхий мөнгөний хариуд тогтмол тооны хувьцаа гаргахад хүргэдэг.*

**20X2 оны 12-р сарын 31.**

*Ямар нэг мөнгө хүлээн авахгүй буюу төлөхгүй бөгөөд тогтмол дүн бүхий мөнгөний хариуд “А” байгууллагын тогтмол тооны өөрийн хувьцааг өгөх үүргийг хүлээлгэдэг гэрээ нь тухайн байгууллагын өмчийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангах учраас 12 дугаар сарын 31-нд бичилт хийхгүй.*

**20X3 оны 01-р сарын 31.**

“Б” байгууллага нь дуудах опционоо хэрэгжүүлсэн бөгөөд уг гэрээг нийт дүнгээр барагдуулсан. “А” байгууллага нь 102,000ТН-ийн мөнгөний хариуд өөрийн 1,000 ширхэг хувьцааг өгөх үүрэгтэй.

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОЛИЛУУЛГА

Дебит	Мөнгө	102,000ТН	
	Кредит Цэвэр хөрөнгө/өмч		102,000ТН

*Опционы гэрээний барагдуулалтыг бүртгэх.*

**(г) Барагдуулалтын сонголтууд**

ҮЖ21. Төлбөр барагдуулах сонголтуудтай (цэвэр мөнгөөр, цэвэр хувьцаагаар, мөнгө ба хувьцааны солилцоогоор гэх мэт) байх нь уг дуудах опционыг санхүүгийн өр төлбөр болгоход хүргэдэг. “А” байгууллага нь тогтмол дүн бүхий мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг хүлээн авсаны хариуд өөрийн тогтмол тооны хувьцааг гаргахаас өөр бусад байдлаар үүнийг барагдуулж болох учраас энэ нь өмчийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангахгүй. “А” байгууллага нь үүсмэл өр төлбөрийг дээрх (а) ба (б)-д үлгэрчлэн харуулсантай адилаар хүлээн зөвшөөрнө. Төлбөр барагдуулалтаар хийх нягтлан бодох бүртгэлийн бичилт нь уг гэрээг бодитойгоор хэрхэн барагдуулснаас хамаардаг.

*Жишээ 5: Хувьцааны, худалдан авсан буцаах опцион*

ҮЖ22. Энэ жишээ нь (а) цэвэр мөнгөөр, (б) цэвэр хувьцаагаар, эсвэл (в) хувьцааны хариуд мөнгө өгснөөр барагдуулах уг байгууллагын өөрийн хувьцааны хувьд худалдан авсан буцаах опционы журналын бичилтүүдийг үлгэрчлэн харуулна. Мөн барагдуулах сонголтуудын үр нөлөөг авч хэлэлцсэн (доорх (г) заалтыг үзнэ үү).

**Таамаглал:**

Гэрээний огноо:	20Х2 оны 02-р сарын 01
Хэрэгжүүлэх огноо:	20Х3 оны 01-р сарын 31

Хэрэгжүүлэх эрхийн эзэмшигч	Тайлагнагч байгууллага ("А" байгууллага)
-----------------------------	---

Нэгж хувьцааны зах зээлийн үнэ, 20Х2 оны 02-р сарын 01	100ТН
Нэгж хувьцааны зах зээлийн үнэ, 20Х2 оны 12-р сарын 31	95ТН
Нэгж хувьцааны зах зээлийн үнэ, 20Х3 оны 01-р сарын 31	95ТН
20Х3 оны 01-р сарын 31-нд төлөгдөх тогтмол хэрэгжүүлэх үнэ	98ТН
Опционы гэрээнд хамаарах хувьцааны тоо	1,000
Опционы бодит үнэ цэнэ, 20Х2 оны 02-р сарын 01	5,000ТН
Опционы бодит үнэ цэнэ, 20Х2 оны 12-р сарын 31	4,000ТН
Опционы бодит үнэ цэнэ, 20Х3 оны 01-р сарын 31	3,000ТН



**(а) Мөнгийг мөнгөөр (“Цэвэр мөнгөн барагдуулалт”)**

ҮЖ23. 20X2 оны 02-р сарын 01-нд “А” байгууллага нь “Б” байгууллагатай гэрээ байгуулсан бөгөөд уг гэрээний дагуу 20X3 оны 01-р сарын 31-нд “А” байгууллага нь эрхийг хэрэгжүүлвэл “Б” байгууллага нь “А” байгууллагын эргэлтэнд буй 1,000 ширхэг энгийн хувьцааг бодит үнэ цэнээр, өөрөөр хэлбэл 20X3 оны 01 дүгээр сарын 31-нээрх 98,000ТН (өөрөөр хэлбэл, нэгж хувьцаанд 98ТН)-ийн хэрэгжүүлэлтийн үнээр худалдан авах үүрэгтэй ба “А” байгууллага нь уг хувьцааг ийм үнээр борлуулах эрхтэй болно. Гэрээг цэвэр мөнгөөр төлж барагдуулна. Хэрэв “А” байгууллага нь өөрийн эрхийг хэрэгжүүлэхгүй бол ямар нэг төлбөр хийгдэхгүй. “А” байгууллага нь дараах журналын бичилт хийнэ.

**20X2 оны 02-сарын 01.**

20X2 оны 02-р сарын 01-нд гэрээг байгуулах үед нэгж хувьцааны үнэ нь 100ТН байсан. 20X2 оны 02-р сарын 01-нд опционы гэрээний анхны бодит үнэ цэнэ нь 5,000ТН байсан бөгөөд “А” байгууллага нь тухайн өдөр энэ дүнг “Б” байгууллагад төлөх юм. Опционы 98ТН-ийн хэрэгжүүлэх үнэ нь нэгж хувьцааны 100ТН-ийн зах зээлийн үнээс бага тул опцион нь тухайн өдөр дотоод үнэ цэнэгүй, зөвхөн цаг хугацааны үнэ цэнэтэй байна. Иймээс опционыг хэрэгжүүлэх нь “А” байгууллагад үр ашиггүй юм. Өөрөөр хэлбэл, буцаах опцион нь мөнгөн алдагдалтай байна.

Дебит	Буцаах опционы хөрөнгө	5,000ТН	
	Кредит Мөнгө		5,000ТН

*Худалдан авсан буцаах опционыг хүлээн зөвшөөрөх.*

**20X2 оны 12-р сарын 31.**

20X2 оны 12-р сарын 31-нд нэгж хувьцааны зах зээлийн үнэ нь 95ТН болж буурсан. Буцаах опционы бодит үнэ цэнэ нь 4,000ТН болж буурсан бөгөөд үүний 3,000ТН ([98ТН–95ТН]x1,000) нь дотоод үнэ цэнэ, 1,000ТН нь үлдэж буй цаг хугацааны үнэ цэнэ байв.

Дебит	Гарз	1,000ТН	
	Кредит Буцаах опционы хөрөнгө		1,000ТН

*Буцаах опционы бодит үнэ цэнийн бууралтыг бүртгэх.*

**20X3 оны 01-р сарын 31.**

20X3 оны 01-р сарын 31-нд нэгж хувьцааны зах зээлийн үнэ нь 95ТН хэвээр байсан. Буцаах опционы бодит үнэ цэнэ нь 3,000ТН болж буурсан бөгөөд цаг хугацааны үнэ цэнэ үлдээгүй тул энэ үнэ нь бүгдээрээ ([98ТН–95ТН]x1,000) дотоод үнэ цэнэ болно.

Дебит	Гарз	1,000ТН	
	Кредит Буцаах опционы хөрөнгө		1,000ТН

*Дуудах опционы бодит үнэ цэнийн бууралтыг бүртгэх.*

Мөн энэ өдөр “А” байгууллага нь буцаах опционоо хэрэгжүүлсэн бөгөөд уг гэрээг цэвэр мөнгөөр барагдуулсан. “Б” байгууллага нь “А” байгууллагад 98,000ТН-ийг өгөх үүрэгтэй ба “А” байгууллага нь “Б” байгууллагад 95,000ТН (95ТНх1,000)-ийг өгөх үүрэгтэй, иймээс “Б” байгууллага нь 3,000ТН-ийн цэвэр дүнг “А” байгууллагад төлсөн.

Дебит	Мөнгө	3,000ТН	
	Кредит Буцаах опционы хөрөнгө		3,000ТН

*Опционы гэрээний барагдуулалтыг бүртгэх.*

**(б) Хувьцааг хувьцаагаар (“Цэвэр хувьцаагаарх барагдуулалт”)**

ҮЖ24. Төлбөрийг цэвэр мөнгөөр хийнэ гэдгийн оронд цэвэр хувьцаагаар барагдуулахаас бусад нөхцөл нь дээрх (а)-д дурдсантай ижил гэж үзье. Доор дурдсанаас бусад тохиолдолд “А” байгууллагын хийх журналын бичилтүүд нь дээрх (а)-д харуулсан журналын бичилттэй ижил байна.

**20Х3 оны 01-р сарын 31.**

“А” байгууллага нь буцаах опционоо хэрэгжүүлсэн бөгөөд уг гэрээг цэвэр хувьцаагаар барагдуулсан. Үнэн хэрэгтээ, “Б” байгууллага нь “А” байгууллагын 98,000ТН-ийн үнэ цэнэтэй хувьцааг түүнд өгөх үүрэгтэй ба “А” байгууллага нь өөрийн 95,000ТН (95ТНх1,000)-ийн үнэ цэнэтэй хувьцааг “Б” байгууллагад өгөх үүрэгтэй. Иймээс “Б” байгууллага нь цэвэр дүнгээр 3,000ТН-ийн үнэ цэнэтэй хувьцааг, өөрөөр хэлбэл 31.6 ширхэг (3,000ТН/95ТН) хувьцааг “А” байгууллагад өгнө.

Дебит	Цэвэр хөрөнгө/өмч	3,000ТН	
	Кредит Буцаах опционы хөрөнгө		3,000ТН

*Опционы гэрээний барагдуулалтыг бүртгэх.*

**(в) Хувьцааг мөнгөөр (“Нийт биет барагдуулалт”)**

ҮЖ25. Хэрэв “А” байгууллага нь опционыг хэрэгжүүлвэл тогтмол дүн бүхий мөнгө хүлээн авах ба өөрийн тогтмол тооны хувьцааг өгснөөр төлбөрийг барагдуулахаас бусад нөхцөл нь дээрх (а)-д дурдсантай ижил гэж үзье. Дээрх (а) ба (б)-д дурдсантай адилаар, нэгж хувьцааны хэрэгжүүлэлтийн үнэ нь тогтмол 98ТН байна. Иймээс “А” байгууллага нь опционоо хэрэгжүүлвэл “Б” байгууллага нь “А” байгууллагын эргэлтэнд буй 1,000 ширхэг хувьцааны хариуд 98,000ТН (98ТН х1,000)-ийн мөнгийг “А” байгууллагад төлөх үүрэгтэй байна. “А” байгууллага нь дараах журналын бичилт хийнэ:

**20Х2 оны 02-р сарын 01.**

Дебит	Цэвэр хөрөнгө/өмч	5,000ТН	
	Кредит Мөнгө		5,000ТН

*Нэг жилийн дараа “А” байгууллага өөрийн хувьцааг тогтмол үнээр өгөх эрхийн хариуд хүлээн авсан мөнгийг бүртгэх. Төлсөн урамшууллыг цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрнө. Опционыг хэрэгжүүлснээр энэ нь тогтмол мөнгөн дүнгийн хариуд тогтмол тооны хувьцааг гаргах үр дүнтэй байна.*

**20Х2 оны 12-р сарын 31.**

*Ямар нэг мөнгө төлөхгүй буюу хүлээн авахгүй бөгөөд тогтмол дүн бүхий мөнгөний хариуд “А” байгууллагын тогтмол тооны өөрийн хувьцааг өгөх ээрээ нь “А” байгууллагын өмчийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангах учраас 12 дугаар сарын 31-нд бичилт хийхгүй.*

**20Х3 оны 01-р сарын 31.**

“А” байгууллага нь буцаах опционоо хэрэгжүүлсэн бөгөөд уг гэрээг нийт дүнгээр барагдуулсан. “Б” байгууллага нь 1,000 ширхэг хувьцааны хариуд 98,000ТН-ийн мөнгийг “А” байгууллагад өгөх үүрэгтэй.

Дебит	Мөнгө	98,000ТН	
	Кредит Цэвэр хөрөнгө/өмч		98,000ТН

*Опционы гэрээний барагдуулалтыг бүртгэх.*

**(г) Барагдуулалтын сонголтууд**

ҮЖ26. Төлбөр барагдуулах сонголтуудтай (цэвэр мөнгөөр, цэвэр хувьцаагаар, мөнгө ба хувьцааны солилцоогоор гэх мэт) байх нь уг буцаах опционыг санхүүгийн хөрөнгө болгоход хүргэдэг. “А” байгууллага нь тогтмол дүн бүхий мөнгө буюу бусад санхүүгийн хөрөнгийг хүлээн авсаны хариуд өөрийн тогтмол тооны хувьцааг гаргахаас өөр бусад байдлаар барагдуулж болох учраас энэ нь өмчийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангахгүй. “А” байгууллага нь үүсмэл хөрөнгийг дээрх (а) ба (б)-д үлгэрчлэн харуулсантай адилаар хүлээн зөвшөөрнө. Төлбөр барагдуулалтаар хийх нягтлан бодох бүртгэлийн бичилт нь уг гэрээг бодитойгоор хэрхэн барагдуулснаас хамаардаг.

**Жишээ б: Хувьцааны гаргасан буцаах опцион**

ҮЖ27. Энэ жишээ нь (а) цэвэр мөнгөөр, (б) цэвэр хувьцаагаар, эсвэл (в) хувьцааны хариуд мөнгө өгснөөр барагдуулах уг байгууллагын өөрийн хувьцааны хувьд гаргасан буцаах опционы журналын бичилтүүдийг үлгэрчлэн харуулна. Мөн барагдуулах сонголтуудын үр нөлөөг авч хэлэлцсэн (доорх (г) заалтыг үзнэ үү).

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОЛИЛУУЛГА

**Таамаглал:**

Гэрээний огноо: 20X2 оны 02-р сарын 01  
 Хэрэгжүүлэх огноо: 20X3 оны 01-р сарын 31  
 (Европын нэр томъёо, өөрөөр хэлбэл, үүнийг зөвхөн дуусгавар болох үед хэрэгжүүлнэ)

Хэрэгжүүлэх эрхийн эзэмшигч	Нөгөө байгууллага ("Б" байгууллага)	
Нэгж хувьцааны зах зээлийн үнэ, 20X2 оны 02-р сарын 01		100ТН
Нэгж хувьцааны зах зээлийн үнэ, 20X2 оны 12-р сарын 31		95ТН
Нэгж хувьцааны зах зээлийн үнэ, 20X3 оны 01-р сарын 31		95ТН
20X3 оны 01-р сарын 31-нд төлөгдөх тогтмол хэрэгжүүлэх үнэ		98ТН
Хэрэгжүүлэх үнийн өнөөгийн үнэ цэнэ, 20X2 оны 02-р сарын 01		95ТН
Опционы гэрээнд хамаарах хувьцааны тоо		1,000
Опционы бодит үнэ цэнэ, 20X2 оны 02-р сарын 01		5,000ТН
Опционы бодит үнэ цэнэ, 20X2 оны 12-р сарын 31		4,000ТН
Опционы бодит үнэ цэнэ, 20X3 оны 01-р сарын 31		3,000ТН

**(a) Мөнгийг мөнгөөр ("Цэвэр мөнгөн барагдуулалт")**

ҮЖ28. "А" байгууллага нь өөрийн хувьцааны хувьд худалдан авсан буцаах опционтой байна гэдгийн оронд гаргасан буцаах опционтой гэдгээс бусад нөхцөл нь дээрх Жишээ 5(а)-д дурдсантай ижил гэж үзье. Иймээс 20X2 оны 02-р сарын 01-нд "А" байгууллага нь "Б" байгууллагатай гэрээ байгуулсан бөгөөд уг гэрээний дагуу 20X3 оны 01-р сарын 31-нд "Б" байгууллага нь эрхийг хэрэгжүүлвэл "А" байгууллага нь 98,000ТН-ийн (өөрөөр хэлбэл, нэгж хувьцаанд 98ТН) мөнгөний хариуд өөрийн эргэлтэнд буй 1,000 ширхэг энгийн хувьцааны 20X3 оны 01-р сарын 31-ний бодит үнэ цэнийг төлөх үүрэгтэй ба "Б" байгууллага нь уг бодит үнэ цэнийг авах эрхтэй болсон. Гэрээг цэвэр мөнгөөр төлж барагдуулна. Хэрэв "Б" байгууллага нь өөрийн эрхийг хэрэгжүүлэхгүй бол ямар нэг төлбөр хийгдэхгүй. "А" байгууллага нь дараах журналын бичилт хийнэ.

**20X2 оны 02-р сарын 01.**

Дебит	Мөнгө	5,000ТН	
	Кредит	Буцаах опционы өр төлбөр	5,000ТН

*Гаргасан буцаах опционыг хүлээн зөвшөөрөх.*

**20X2 оны 12-р сарын 31.**

Дебит	Буцаах опционы өр төлбөр	1,000ТН	
	Кредит	Олз	1,000ТН

*Буцаах опционы бодит үнэ цэнийн бууралтыг бүртгэх.*

**20X3 оны 01-р сарын 31.**

Дебит	Буцаах опционы өр төлбөр	1,000ТН	
	Кредит	Олз	1,000ТН

*Буцаах опционы бодит үнэ цэнийн бууралтыг бүртгэх.*

Мөн энэ өдөр “Б” байгууллага нь буцаах опционоо хэрэгжүүлсэн бөгөөд уг гэрээг цэвэр мөнгөөр барагдуулсан. “А” байгууллага нь “Б” байгууллагад 98,000ТН-ийг өгөх үүрэгтэй, “Б” байгууллага нь 95,000ТН (95ТНх1,000)-ийг “А” байгууллагад өгөх үүрэгтэй. Иймээс “А” байгууллага нь цэвэр дүнгээр 3,000ТН-ийг “Б” байгууллагад төлсөн.

Дебит	Буцаах опционы өр төлбөр	3,000ТН	
	Кредит	Мөнгө	3,000ТН

*Опционы гэрээний барагдуулалтыг бүртгэх.*

**(б) Хувьцааг хувьцаагаар (“Цэвэр хувьцаагаарх төлбөр”)**

ҮЖ29. Төлбөрийг цэвэр мөнгөөр хийнэ гэдгийн оронд цэвэр хувьцаагаар барагдуулахаас бусад нөхцөл нь дээрх (а)-д дурдсантай ижил гэж үзье. Доор дурдсанаас бусад тохиолдолд “А” байгууллагын хийх журналын бичилтүүд нь дээрх (а)-д харуулсан журналын бичилттэй ижил байна.

**20X3 оны 12-р сарын 31.**

“Б” байгууллага нь буцаах опционоо хэрэгжүүлсэн бөгөөд уг гэрээг цэвэр хувьцаагаар барагдуулсан. Үнэн хэрэгтээ, “А” байгууллага нь өөрийн 98,000ТН-ийн үнэ цэнэтэй хувьцааг “Б” байгууллагад өгөх үүрэгтэй ба “Б” байгууллага нь “А” байгууллагын 95,000ТН (95ТНх1,000)-ийн үнэ цэнэтэй хувьцааг түүнд өгөх үүрэгтэй. Иймээс “А” байгууллага нь цэвэр дүнгээр 3,000ТН-ийн үнэ цэнэтэй өөрийн хувьцааг, өөрөөр хэлбэл 31.6 ширхэг (3,000ТН/95ТН) хувьцааг “Б” байгууллагад өгнө.

Дебит	Буцаах опционы өр төлбөр	3,000ТН	
	Кредит	Цэвэр хөрөнгө/өмч	3,000ТН

*Опционы гэрээний барагдуулалтыг бүртгэх. “А” байгууллагын өөрийн хувьцааны гаргалтыг цэвэр хөрөнгө/өмчийн ажил гүйлгээтэй адилаар тайлагнана.*

**(в) Хувьцааг мөнгөөр (“Нийт биет барагдуулалт”)**

ҮЖ30. Хэрэв “Б” байгууллага нь опционыг хэрэгжүүлвэл тогтмол дүн бүхий мөнгө өгөх ба тогтмол тооны хувьцааг авснаар төлбөрийг барагдуулахаас бусад нөхцөл нь дээрх (а)-д дурдсантай ижил гэж үзье. Дээрх (а) ба (б)-д дурдсантай адилаар, нэгж хувьцааны хэрэгжүүлэлтийн үнэ нь тогтмол 98ТН байна. Иймээс “Б” байгууллага нь опционоо хэрэгжүүлвэл “А” байгууллага нь өөрийн эргэлтэнд буй 1,000 ширхэг хувьцааны хариуд 98,000ТН (98ТН х1,000)-ийн мөнгийг “Б” байгууллагад төлөх үүрэгтэй болно. Иймээс “А” байгууллага нь дараах журналын бичилт хийнэ:

**20X2 оны 02-р сарын 01.**

Дебит	Цэвэр хөрөнгө/өмч	5,000ТН	
	Кредит Мөнгө		5,000ТН

*Хүлээн авсан 5,000ТН-ийн опционы урамшууллыг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрөх.*

Дебит	Цэвэр хөрөнгө/өмч	95,000ТН	
	Кредит Өр төлбөр		95,000ТН

*Нэг жилийн дараа 98,000ТН-ийг төлөх үүргийн өнөөгийн үнэ цэнийг, өөрөөр хэлбэл 95,000ТН-ийг өр төлбөр гэж хүлээн зөвшөөрөх.*

**20X2 оны 12-р сарын 31.**

Дебит	Хүүний зардал	2,750ТН	
	Кредит Өр төлбөр		2,750ТН

*Хувьцааг эргэлтээс гаргах өр төлбөрийн хувьд үр ашигтай хүүний аргын дагуу хүүг хуримтлуулан бүртгэх.*

**20X3 оны 01-р сарын 31.**

Дебит	Хүүний зардал	250ТН	
	Кредит Өр төлбөр		250ТН

*Хувьцааг эргэлтээс гаргах өр төлбөрийн хувьд үр ашигтай хүүний аргын дагуу хүүг хуримтлуулан бүртгэх.*

Мөн энэ өдөр “Б” байгууллага нь буцаах опционоо хэрэгжүүлсэн бөгөөд уг гэрээг нийт дүнгээр барагдуулсан. “А” байгууллага нь 95,000ТН (95ТНх1,000)-ийн үнэ цэнэтэй хувьцааны хариуд “Б” байгууллагад 98,000ТН-ийн мөнгө өгөх үүрэгтэй.

Дебит	Өр төлбөр	98,000ТН	
	Кредит Мөнгө		98,000ТН

*Опционы гэрээний барагдуулалтыг бүртгэх.*

**(г) Барагдуулалтын сонголтууд**

ҮЖ31. Төлбөр барагдуулах сонголтуудтай (цэвэр мөнгөөр, цэвэр хувьцаагаар, мөнгө ба хувьцааны солилцоогоор гэх мэт) байх нь уг гаргасан буцаах опционыг санхүүгийн өр төлбөр болгоход хүргэдэг. Төлбөр барагдуулах хувилбаруудын нэг нь хувьцааг мөнгөөр солилцох (дээрх (в) гэх мэт) явдал бол “А” байгууллага нь дээрх (в)-д харуулсанчлан, мөнгө өгөх үүргийн хувьд өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Үүнээс бусад тохиолдолд “А” байгууллага нь буцаах опционыг үүсмэл өр төлбөр гэж тайлагнана.

**Хувьцаат капитал нь цэвэр хөрөнгө/өмч биш байх хамтын сан ба хоршоо гэх мэт байгууллагууд**

*Жишээ 7: Цэвэр хөрөнгө/өмчгүй байгууллагууд*

ҮЖ32. Цэвэр хөрөнгө/өмчгүй хамтын сан гэх мэт байгууллагуудын ашиглаж болох санхүүгийн үр дүнгийн тайлан болон санхүүгийн байдлын тайлангийн загварыг дараах жишээнд үлгэрчлэн харуулав. Бусад хэлбэр загварууд байж болох юм.

**20X1 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жилийн Санхүүгийн үр дүнгийн тайлан**

	<b>20X1</b>	<b>20X0</b>
	ТН	ТН
Орлого	2,956	1,718
Нийт орлого	<u>2,956</u>	<u>1,718</u>
Зардал (шинж төрөл буюу чиг үүргээр ангилсан)	(644)	(614)
Санхүүгийн зардал		
- бусад санхүүгийн зардал	(47)	(47)
- нэгж хувь оролцооны эзэмшигчдэд олгосон хуваарилалт	(50)	(50)
Нийт зардал	<u>(741)</u>	<u>(711)</u>
Тухайн жилийн ашиг	<u>2,215</u>	<u>1,007</u>
Нэгж хувь оролцооны эзэмшигчдэд хамаарах цэвэр хөрөнгийн өөрчлөлт	<u>2,215</u>	<u>1,007</u>

**20X1 оны 12-р сарын 31-ний Санхүүгийн байдлын тайлан**

	<b>20X1</b>		<b>20X0</b>	
	ТН	ТН	ТН	ТН
<b>ХӨРӨНГӨ</b>				
Эргэлтийн бус хөрөнгө (УСНББОУС 1-ийн дагуу ангилсан)	91,374		78,484	
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>		91,374		78,484
Эргэлтийн хөрөнгө (УСНББОУС 1-ийн дагуу ангилсан)	<u>1,422</u>		<u>1,769</u>	

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОЛИЛУУЛГА

<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<u>1,422</u>	<u>1,769</u>
<b>Нийт хөрөнгө</b>	<b>92,796</b>	<b>80,253</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>		
Богино хугацаат өр төлбөр (УСНББОУС 1-ийн дагуу ангилсан)	<u>647</u>	<u>66</u>
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	(647)	(66)
Урт хугацаат өр төлбөр, нэгж хувь оролцоо эзэмшигчдэд хамаарах цэвэр хөрөнгийг оруулаагүй (УСНББОУС 1-ийн дагуу ангилсан)	<u>280</u>	<u>136</u>
	(280)	(136)
<b>Нэгж хувь оролцоо эзэмшигчдэд хамаарах цэвэр хөрөнгө</b>	<b>91,869</b>	<b>80,051</b>

*Жишээ 8: Зарим цэвэр хөрөнгө/өмчтэй байгууллагууд*

ҮЖЗЗ. Байгууллага нь хувьцаат капиталыг шаардлагын дагуу буцаан төлөх үүрэгтэй учраас түүний хувьцаат капитал нь цэвэр хөрөнгө/өмч биш байх байгууллагуудын ашиглаж болох санхүүгийн үр дүнгийн тайлан болон санхүүгийн байдлын тайлангийн загварыг дараах жишээнд үлгэрчлэн харуулав. Бусад хэлбэр загварууд байж болох юм.

**20X1 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жилийн Санхүүгийн үр дүнгийн тайлан**

	<b>20X1</b>	<b>20X0</b>
	ТН	ТН
Орлого	472	498
Нийт орлого	<u>472</u>	<u>498</u>
Зардал (шинж төрөл буюу чиг үүргээр ангилсан)	(367)	(396)
Санхүүгийн зардал		
- бусад санхүүгийн зардал	(4)	(4)
- нэгж хувь оролцооны эзэмшигчдэд олгосон хуваарилалт	(50)	(50)
Нийт зардал	<u>(421)</u>	<u>(450)</u>
Тухайн жилийн ашиг	<u>51</u>	<u>48</u>
Гишүүдэд хамаарах цэвэр хөрөнгийн өөрчлөлт	<u>51</u>	<u>48</u>



САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОЛИЛУУЛГА

**20X1 оны 12-р сарын 31-ний Санхүүгийн байдлын тайлан**

	ТН	20X1 ТН	ТН	20X0 ТН
<b>ХӨРӨНГӨ</b>				
Эргэлтийн бус хөрөнгө (УСНББОУС 1-ийн дагуу ангилсан)	908		830	
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>		908		830
Эргэлтийн хөрөнгө (УСНББОУС 1-ийн дагуу ангилсан)	383		350	
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>		383		350
<b>Нийт хөрөнгө</b>		<b>1,291</b>		<b>1,180</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>				
Богино хугацаат өр төлбөр (УСНББОУС 1-ийн дагуу ангилсан)	372		338	
<b>Шаардлагын дагуу буцаан төлөх хувьцаат капитал</b>	202		161	
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>		(574)		(499)
<b>Богино хугацаат өр төлбөрийг хассан нийт хөрөнгө</b>		<b>717</b>		<b>681</b>
Урт хугацаат өр төлбөр (УСНББОУС 1-ийн дагуу ангилсан)	187		196	
		(187)		(196)
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН БУСАД БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮД<sup>(a)</sup></b>				
Нөөц сан, жишээлбэл; дахин үнэлгээний нөөц, хуримтлагдсан ашиг гэх мэт	530		485	
		530		485
		717		681
<b>САНАМЖ ТЭМДЭГЛЭЛ-Гишүүдийн нийт хувь оролцоо</b>				
Шаардлагаар буцаан төлөх хувьцаат капитал		202		161
Нөөц сан		530		485
		732		646

(a) Энэхүү жишээнд байгууллага нь өөрийн нөөцийн хувь оролцоог гишүүддээ өгөх үүрэггүй байна.

## Нийлмэл санхүүгийн хэрэглүүрийн тайлагнал

*Жишээ 9: Анх хүлээн зөвшөөрөх үед нийлмэл санхүүгийн хэрэглүүрийг салган зааглах*

ҮЖ34. Байгууллага нь анх хүлээн зөвшөөрөх үедээ нийлмэл санхүүгийн хэрэглүүрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрхэн салган зааглахыг 33-р параграфт заасан. Ийм салган зааглалтыг хэрхэн хийхийг дараах жишээнд үлгэрчлэн харуулав.

ҮЖ35. Байгууллага нь 1 дэх жилийн эхэнд 2,000 ширхэг хөрвөх бонд гаргасан. Бонд нь 3 жилийн хугацаатай бөгөөд нэгж бондыг 1,000ТН-ийн нэрлэсэн үнээр гаргаж, нийт 2,000,000ТН-ийн мөнгөн орлого орсон. Хүүг жилийн 6 хувийн нэрлэсэн хүүгээр тооцож, жил бүр төлнө. Бонд бүр нь дуусгавар хугацаа хүртэлх дурын хугацаанд 250 ширхэг энгийн хувьцаанд хөрвөх боломжтой. Хөрвөх эрхгүй адилтгах бондын зах зээлийн хүү болох 9 хувийн дискаунтын түвшинг ашигласнаар уг өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсгийн өнөөгийн үнэ цэнийг дараах байдлаар тооцоолно:

	ТН
Үндсэн дүнгийн өнөөгийн үнэ цэнэ-гурван жилийн эцэст төлөх 2,000,000ТН	1,544,367
Хүүний өнөөгийн үнэ цэнэ-гурван жилийн туршид жил бүр төлөх 120,000ТН	303,755
Өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсгийн дүн	<u>1,848,122</u>
Цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсэг (хассанаар)	<u>151,878</u>
Бонд гаргалтын мөнгөн орлого	<u>2,000,000</u>

*Жишээ 10: Дагалдах олон үүсмэл шинжүүд бүхий нийлмэл санхүүгийн хэрэглүүрийн салган зааглалт*

ҮЖ37. Дагалдах олон үүсмэл шинжүүд бүхий нийлмэл санхүүгийн хэрэглүүрийг түүний өр төлбөрийн болон цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдэд салган зааглахдаа 36-р параграфыг хэрхэн мөрдөхийг дараах жишээнд үлгэрчлэн харуулав.

ҮЖ38. Дуудах боломжтой хөрвөх бондын гаргалтаар хүлээн авсан мөнгөн орлого нь 60ТН байсан гэж үзье. Дуудах буюу өмчид хөрвөх опционгүй, адилтгах бондын үнэ цэнэ нь 57ТН байсан. Өмчид хөрвөх опционгүй адилтгах бондын хувьд дагалдах дуудах шинжийн тухайн байгууллага дахь үнэ цэнэ нь 2ТН гэдгийг опционы үнэ тогтоох загварт үндэслэн тодорхойлсон. Энэ тохиолдолд 36-р параграфын дагуу өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсэгт хуваарилагдах үнэ цэнэ нь 55ТН (57ТН-2ТН), харин цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсэгт хуваарилагдах үнэ цэнэ нь 5ТН (60ТН-55ТН) болно.

*Жишээ 11: Хөрвөх хэрэглүүрийн буцаан худалдан авалт*

- ҮЖ39. Байгууллага нь хөрвөх хэрэглүүрийн буцаан худалдан авалтаа хэрхэн тайлагнахыг дараах жишээнд үлгэрчлэн харуулсан. Хялбарчлах үүднээс, эхлэлийн өдөр уг хэрэглүүрийн нэрлэсэн үнэ нь санхүүгийн тайлан дахь тухайн өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгүүдийн дансны үнүүдийн нийт дүнтэй тэнцүү байсан, өөрөөр хэлбэл анх гаргах үед урамшуулал эсвэл хөнгөлөлт байгаагүй гэж үзье. Мөн хялбарчлах үүднээс энэ жишээнд татварын нөлөөллийг оруулаагүй болно.
- ҮЖ40. 20X0 оны 01-р сарын 01-нд “А” байгууллага нь 1,000ТН-ийн нэрлэсэн үнэтэй ба 20X9 оны 12-р сарын 31-нд дуусгавар болох, 10 хувийн хүүтэй, хөрвөх өрийн бичиг гаргасан. Уг өрийн бичиг нь “А” байгууллагын энгийн хувьцаанд хөрвөх боломжтой бөгөөд нэгж хувьцаанд хөрвөх үнэ нь 25ТН байсан. Хүүг хагас жил тутамд мөнгөөр төлнө. Энэхүү гаргалтын өдөр “А” байгууллага нь тасалбартаа 11 хувийн хүүтэй, 10 жилийн хугацаатай, үл хөрвөх өрийн бичгийг гаргах боломжтой байсан.
- ҮЖ41. Уг өрийн бичгийн дансны үнийг гаргах үед “А” байгууллагын санхүүгийн тайланд дараах байдлаар хуваарилсан:

	ТН
<b>Өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсэг</b>	
50ТН-ээр хагас жил тутам төлөх 20 удаагийн хүүний төлбөрийн 11 хувиар дискаунтчилсан өнөөгийн үнэ цэнэ	597
10 жилийн дараа төлөх 1,000ТН-ийн жилийн 11 хувийн, хагас жил тутамд нийлмэл хүүгээр дискаунтчлан тооцсон өнөөгийн үнэ цэнэ	343
	940
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсэг</b>	
(1,000ТН-ийн нийт мөнгөн орлого ба дээр дурдсан байдлаар хуваарилсан 940ТН-ийн хоорондох зөрүү)	60
<b>Нийт мөнгөн орлого</b>	<b>1,000</b>

- ҮЖ42. 20X5 оны 01-р сарын 01-нд уг хөрвөх өрийн бичиг нь 1,700ТН-ийн бодит үнэ цэнэтэй байсан.
- ҮЖ43. “А” байгууллага нь өрийн бичгийг 1,700ТН-ээр буцаан худалдан авах саналыг тухайн өрийн бичгийн эзэмшигчид тавьсан бөгөөд уг эзэмшигч нь зөвшөөрсөн. Энэхүү буцаан худалдан авалтын өдөр “А” байгууллага нь тасалбартаа 8 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай, үл хөрвөх өрийн бичгийг гаргах боломжтой байсан.

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ТОЛИЛУУЛГА

ҮЖ44. Буцаан худалдан авах үнийг дараах байдлаар хуваарилсан:

	Дансны үнэ	Бодит үнэ цэнэ	Зөрүү
	TН	TН	TН
<b>Өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсэг:</b>			
50ТН-ээр хагас жил тутам төлөх 10 удаагийн үлдсэн хүүний төлбөрийн өнөөгийн үнэ цэнэ, 11 хувь ба 8 хувиар дискаунтчилсан	377	405	
5 жилийн дараа төлөх 1,000ТН-ийн хагас жил тутамд нийлмэл хүүгээр дискаунтчлан тооцсон өнөөгийн үнэ цэнэ, 11 хувь ба 8 хувиар дискаунтчилсан	585	676	
	962	1,081	(119)
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсэг</b>	60	619 <sup>(a)</sup>	(559)
<b>Нийт дүн</b>	<b>1,022</b>	<b>1,700</b>	<b>(678)</b>

(a) Энэхүү дүн нь өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсэгт хуваарилсан бодит үнэ цэнийн дүн ба 1,700ТН-ийн буцаан худалдан авалтын үнэ хоорондох зөрүүг илэрхийлнэ.

ҮЖ45. “А” байгууллага нь уг өрийн бичгийн буцаан худалдан авалтыг дараах байдлаар хүлээн зөвшөөрсөн:

Дебит	Өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсэг	962ТН	
Дебит	Өр барагдуулалтын зардал (ашиг, алдагдал)	119ТН	
Кредит	Мөнгө		1,081ТН

*Өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсгийн буцаан худалдан авалтыг хүлээн зөвшөөрөх.*

Дебит	Цэвэр хөрөнгө/өмч	619ТН	
Кредит	Мөнгө		619ТН

*Цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсгийн хувьд төлсөн мөнгийг хүлээн зөвшөөрөх.*

ҮЖ46. Цэвэр хөрөнгө/өмчийн бүрэлдэхүүн хэсэг нь цэвэр хөрөнгө/өмч хэвээрээ үлдэх боловч цэвэр хөрөнгө/өмчийн доторх нэг мөрөөс нөгөө мөрийн хооронд шилжүүлж болох юм.

*Жишээ 12: Эрт хөрвүүлэлтэнд дэмжлэг үзүүлэхийн тулд хөрвөх хэрэглүүрийн нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах*

- ҮЖ47. Эрт хөрвүүлэлтэнд дэмжлэг үзүүлэхийн тулд уг хөрвөх хэрэглүүрийн нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулах үед төлсөн нэмэлт төлбөрийг тухайн байгууллага хэрхэн тайлагнахыг дараах жишээнд үлгэрчлэн харуулав.
- ҮЖ48. 20X0 оны 01-р сарын 01-нд “А” байгууллага нь 1,000ТН-ийн нэрлэсэн үнэтэй, 10 хувийн хүүтэй, хөрвөх өрийн бичгийг дээрх Жишээ 9-д дурдсантай ижил нөхцлөөр гаргасан. Хөрвөх өрийн бичгийг нэн даруй хөрвүүлэхэд түүний эзэмшигчид дэмжлэг үзүүлэхийн тулд 20X1 оны 01-р сарын 01-нд “А” байгууллага нь хэрэв уг өрийн бичгийг 20X1 оны 3-р сарын 01-нээс өмнө (өөрөөр хэлбэл, 60 хоногийн дотор) хөрвүүлвэл хөрвүүлэлтийн үнийг 20ТН болгож бууруулахаа илэрхийлсэн.
- ҮЖ49. Энэхүү нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулсан өдөр “А” байгууллагын нэгж энгийн хувьцааны зах зээлийн үнэ нь 40ТН байсан гэж үзье. “А” байгууллагын төлөх өсөн нэмэгдсэн төлбөрийн бодит үнэ цэнийг дараах байдлаар тооцоолсон:

***Нэмэлт өөрчлөлт оруулсан хөрвүүлэлтийн нөхцлийн дагуу өрийн бичгийн эзэмшигчдэд гаргах энгийн хувьцааны тоо:***

Нэрлэсэн үнэ	1,000ТН	
Шинэ хөрвүүлэлтийн үнэ	<u>/20ТН</u>	Нэгж хувьцаанд
Хөрвүүлэлтээр гаргах энгийн хувьцааны тоо	<u>50</u>	Хувьцааны тоо

***Анхны хөрвүүлэлтийн нөхцлийн дагуу өрийн бичгийн эзэмшигчдэд гаргах энгийн хувьцааны тоо:***

Нэрлэсэн үнэ	1,000ТН	
Анхны хөрвүүлэлтийн үнэ	<u>/25ТН</u>	Нэгж хувьцаанд
Хөрвүүлэлтээр гаргах энгийн хувьцааны тоо	40	Хувьцааны тоо
<i>Хөрвүүлэлтээр гаргах өсөн нэмэгдсэн энгийн хувьцааны тоо</i>	10	Хувьцааны тоо
<i>Хөрвүүлэлтээр гаргах өсөн нэмэгдсэн энгийн хувьцааны үнэ цэнэ</i>		
Нэгж хувьцааны 40ТН х 10 ширхэг өсөн нэмэгдсэн хувьцаа	<u>400ТН</u>	

- ҮЖ50. Өсөн нэмэгдсэн 400ТН-ийн төлбөрийг ашиг, алдагдалд гарз гэж хүлээн зөвшөөрнө.

## НББОУС 32-ТОЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 28, *Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга*-ыг НББОУС 32, *Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга* (анх 2003 онд гаргасан ба 2008 оны 12 дугаар сарын 31 хүртэлх нэмэлт өөрчлөлтүүдийг тусгасан)-аас үндсэндээ бэлтгэсэн. УСНББОУС 28 ба НББОУС 32-ын хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- Байгууллага нь санхүүгийн баталгааны гэрээг өмнө нь даатгалын гэрээ гэж үздэг байсан тохиолдолд ийм байдлаар авч үзэхийг НББОУС 32 нь зөвшөөрдөг. Байгууллага нь санхүүгийн баталгааны гэрээг даатгалын гэрээ гэж илт тодорхой илэрхийлэх шаардлагагүй байхаас бусад тохиолдолд УСНББОУС 28 нь адилтгах сонголт хийхийг зөвшөөрдөг.
- УСНББОУС 28 нь зарим тохиолдолд НББОУС 32-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь “санхүүгийн үр дүнгийн тайлан” ба “цэвэр хөрөнгө/өмч” гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. НББОУС 32 дахь адилтгах нэр томъёо нь “дэлгэрэнгүй орлогын тайлан буюу тусдаа орлогын тайлан (хэрэв толилуулдаг бол)” ба “өмч” юм.
- УСНББОУС 28 нь “орлого” /revenue/ ба “орлого” /income/ нэр томъёог өөр хооронд нь ялган авч үздэггүй. НББОУС 32-ын хувьд “орлого” /income/ нэр томъёо нь “орлого” /revenue/ нэр томъёоноос илүү өргөн утгатай байдаг бөгөөд эдгээр нэр томъёог өөр хооронд нь ялган тодорхойлдог.
- УСНББОУС 28 нь мөн чанарын хувьд гэрээ байх хэлцлийг тодорхойлохтой холбоотой нэмэлт Мөрдөх Заавар Удирдамжийг агуулсан байдаг.
- Арилжааны бус орлогын ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгө ба өр төлбөр нь хэдийд санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөр болох талаархи нэмэлт Мөрдөх Заавар Удирдамжийг УСНББОУС 28 агуулсан байдаг.
- СТОУТХ 2, *Хоршоон дахь Гишүүдийн Хувь Оролцоо ба Адилтгах Хэрэглүүрүүд*-ээс авсан зарчмуудыг УСНББОУС 28-д Хавсралт байдлаар тусган оруулсан.
- УСНББОУС 28-д заасан шилжилтийн нөхцөл нь НББОУС 32-ын шилжилтийн нөхцлөөс өөр байдаг. Яагаад гэвэл, УСНББОУС 28 нь энэ Стандартыг анх удаа мөрдөж буй байгууллагууд эсвэл аккруэл нягтлан бодох бүртгэлийг анх удаа мөрдөж буй байгууллагуудад зориулсан шилжилтийн нөхцлөөр хангадаг.

## УСНББОУС 29–САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

### Мэдэгдэл

Энэхүү Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс хэвлэн гаргасан Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (НББОУС) 39, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Тайлбарын Хороо (СТОУТХ)-ны Тайлбар 9, *Дагалдах Үүсмэл Хэрэглүүрийн Дахин Үнэлэлт* (СТОУТХ 9), СТОУТХ-ны Тайлбар 16, *Гадаад Үйл Ажиллагаанд Оруулсан Цэвэр Хөрөнгө Оруулалтын Хейж* (СТОУТХ 16)-аас үндсэндээ бэлтгэсэн болно. НББОУС 39, СТОУТХ 9, СТОУТХ 16-гаас авсан ишлэлүүдийг Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ)-ны Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ)-ийн энэ хэвлэлд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын Сангийн зөвшөөрөлтэйгээр дахин нийтэлсэн.

Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын батлагдсан текст нь НББОУСЗ-өөс англи хэл дээр хэвлэсэн хувилбар бөгөөд түүний хуулбар хувиудыг Их Британи, Лондон EC4M 6XH, 30 Каннон гудамж, Нэгдүгээр давхар хаягаар СТОУС-ын Сангийн Хэвлэлийн Хэлтсээс шууд авч болно.

Цахим шуудан: [publications@ifrs.org](mailto:publications@ifrs.org)

Вэб сайт: [www.ifrs.org](http://www.ifrs.org)

НББОУСЗ-ийн СТОУС, НББОУС, Саналын Төсөл болон бусад хэвлэлүүд нь СТОУС-ын Сангийн зохиогчийн эрхэд хамаарна.

“IFRS”, “IAS”, “IASB”, “IFRS Foundation”, “International Accounting Standards”, “International Financial Reporting Standards” нь СТОУС-ын Сангийн худалдааны тэмдэг бөгөөд СТОУС-ын Сангийн зөвшөөрөлгүйгээр хэрэглэж болохгүй.

## УСНББОУС 29-САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

### УСНББОУС-ЫН ТҮҮХ

Энэ хувилбар нь 2018 оны 01 дүгээр сарын 31 хүртэл гаргасан УСНББОУС-ын үр дүнд хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийг агуулсан болно.

УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт-ийг 2010 оны 01 дүгээр сард гаргасан.

Үүнээс хойш дараах УСНББОУС-ын үр дүнд УСНББОУС 29-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл (2017 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 39, Ажилтны Тэтгэмж (2016 оны 7 дугаар сард гаргасан)
- УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд (2016 оны 4 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 37, Хамтын Хэлэлцээр (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 35, Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх (2015 оны 01 дүгээр сард гаргасан)
- УСНББОУС 32, Үйлчилгээний Концессын Хэлцэл: Эрх бүхий этгээд (2011 оны 10 дугаар сард гаргасан)
- УСНББОУС 2011-ийн Сайжруулалтууд (2011 оны 10 дугаар сард гаргасан)

### УСНББОУС 29-ийн нэмэлт өөрчлөлт оруулсан параграфуудын хүснэгт

Өөрчлөгдсөн параграф	Хэрхэн өөрчилсөн	Юугаар өөрчилсөн
Танилцуулга хэсэг	Хассан	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2011 оны 10-р сар
2	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар УСНББОУС 39, 2016 оны 7-р сар УСНББОУС 37, 2015 оны 01-р сар УСНББОУС 35, 2015 оны 01-р сар УСНББОУС 32, 2011 оны 10-р сар
7	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
8	Хассан	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар



САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

17	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
89	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
114	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
115	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
116	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
117	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
118	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
119	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
120	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
121	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
122	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
123	Хассан	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
125А	Шинэ	УСНББОУС 32, 2011 оны 10-р сар
125Б	Шинэ	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
125В	Шинэ	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
125Г	Шинэ	УСНББОУС-ын Сайжруулалтууд, 2016 оны 4-р сар
125Д	Шинэ	УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал, 2016 оны 4-р сар
125Е	Шинэ	УСНББОУС 39, 2016 оны 7-р сар
125Ж	Шинэ	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
126	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 33, 2015 оны 01-р сар
МЗУ35	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
МЗУ51	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
МЗУ52	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
МЗУ53	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 35, 2015 оны 01-р сар
МЗУ131	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
Б4	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 40, 2017 оны 01-р сар
В2	Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС 37, 2015 оны 01-р сар

2010 оны 01 дүгээр сар

**УСНББОУС 29–САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН  
ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ**

**АГУУЛГА**

	Параграф
Зорилго	1
Цар хүрээ	2-8
Тодорхойлолт	9-10
Дагалдах үүсмэл хэрэглүүр	11-15
Хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлт	16-44
Анхны хүлээн зөвшөөрөлт	16
Санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлт	17-39
Үл хүлээн зөвшөөрөх шалгуур хангах шилжүүлэлт	26-30
Үл хүлээн зөвшөөрөх шалгуур хангахгүй шилжүүлэлт	31
Шилжүүлсэн хөрөнгө дэх цаашдын оролцоо	32-37
Бүх шилжүүлэлт	38-39
Санхүүгийн хөрөнгийн ердийн нөхцлөөр худалдан авалт буюу борлуулалт	40
Санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт	41-44
Хэмжилт	45-79
Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн анхны хэмжилт	45-46
Санхүүгийн хөрөнгийн дараагийн тайлант үеийн хэмжилт	47-48
Санхүүгийн өр төлбөрийн дараагийн тайлант үеийн хэмжилт	49
Бодит үнэ цэнийн хэмжилтийн анхаарах зүйлс	50-52
Дахин ангилал	53-63
Олз ба гарз	64-66
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт ба үл цуглуулагдах байдал	67-79
Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн санхүүгийн хөрөнгө	72-74
Өртгөөр бүртгэсэн санхүүгийн хөрөнгө	75
Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө	76-79
Хейж	80-113
Хейжийн хэрэглүүр	81-86
Шалгуур хангах хейжийн хэрэглүүр	81-82
Хейжийн хэрэглүүрийн сонголт	83-86
Хейжийн зүйлс	87-94
Шалгуур хангах хейжийн ызүйлс	87-89
Санхүүгийн зүйлсийг хейжийн зүйлс гэж сонгох	90-91
Санхүүгийн бус зүйлсийг хейжийн зүйлс гэж сонгох	92
Зүйлсийн бүлгүүдийг хейжийн зүйлс гэж сонгох	93-94
Хейжийн нягтлан бодох бүртгэл	95-113
Бодит үнэ цэнийн хейж	99-105
Мөнгөн гүйлгээний хейж	106-112
Цэвэр хөрөнгө оруулалтын хейж	113

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

Шилжилтийн нөхцөл	114-123
Хүчин төгөлдөр болох хугацаа	124-126
Хавсралт А: Мөрдөх заавар удирдамж	
Хавсралт Б: Дагалдах үүсмэл хэрэглүүрийн дахин үнэлэлт	
Хавсралт В: Гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хейж	
Хавсралт Г: Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт	
Дүгнэлтийн үндэслэл	
Хэрэгжүүлэх заавар удирдамж	
Үлгэрчилсэн жишээ	
НББОУС 39-тэй харьцуулалт	

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*-ийг 1-126-р параграфт тусган илэрхийлсэн. Бүх параграфууд нь адил хүчин төгөлдөр үйлчилнэ. УСНББОУС 29-ийг түүний зорилгын агуулга, Дүгнэлтийн Үндэслэл, *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршил* болон *Улсын Секторын Байгууллагуудын Нийтлэг Зорилготой Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалын* хамт уншвал зохино. Баримтлах тодорхой заавар удирдамж байхгүй тохиолдолд УСНББОУС 3 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгох ба мөрдөх суурь үндэслэлээр хангах юм.

## Зорилго

1. Энэ Стандартын зорилго нь санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөр болон санхүүгийн санхүүгийн бус зүйлсийг худалдан авах буюу борлуулах зарим гэрээг хүлээн зөвшөөрөх ба хэмжих зарчмуудыг тогтооход оршино. Санхүүгийн хэрэглүүрийн талаархи мэдээллийг толилуулах шаардлагуудыг УСНББОУС 28, *Санхүүгийн Хэрэглүүр: Толилуулга*-д заасан. Санхүүгийн хэрэглүүрийн талаархи мэдээллийг тодруулах шаардлагуудыг УСНББОУС 30, *Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга*-д тусгасан.

## Цар хүрээ

2. Бүх байгууллагууд нь доор дурдсанаас бусад бүх төрлийн санхүүгийн хэрэглүүрийн хувьд энэ Стандартыг мөрдөнө:
  - (a) УСНББОУС 34, *Тусдаа Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан*, УСНББОУС 36, *Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт*-ын дагуу тайлагнадаг хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоо. Гэвч зарим тохиолдолд УСНББОУС 34, УСНББОУС 35, УСНББОУС 36 нь хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоог энэхүү Стандартын зарим эсвэл бүх шаардлагуудын дагуу тайлагнахыг байгууллагаас шаарддаг буюу зөвшөөрдөг. Хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоотой холбоотой үүсмэл хэрэглүүр нь УСНББОУС 28-д заасан тухайн байгууллагын өмчийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангахгүй тохиолдолд байгууллагууд нь тэрхүү үүсмэл хэрэглүүрт мөн энэ Стандартыг дагаж мөрдөнө.
  - (б) УСНББОУС 13, *Түрээс*-ийг мөрдөх түрээсийн дагуу үүсэх эрх ба үүрэг. Гэхдээ:
    - (i) Түрээслүүлэгчийн хүлээн зөвшөөрсөн түрээсийн авлага нь энэ Стандартын үл хүлээн зөвшөөрөлтийн болон үнэ цэнийн бууралтын шаардлагуудад захирагдана (17-39, 67, 68, 72-р параграфууд болон Хавсралт А-гийн МЗУ51-МЗУ67, МЗУ117-МЗУ126-р параграфуудыг үзнэ үү);
    - (ii) Түрээслэгчийн хүлээн зөвшөөрсөн санхүүгийн түрээсийн өр төлбөр нь энэ Стандартын үл хүлээн зөвшөөрөлтийн шаардлагуудад захирагдана (41-44-р параграфууд болон Хавсралт А-гийн МЗУ72-МЗУ80-р параграфуудыг үзнэ үү);
    - (iii) Түрээсийг дагалдан үүсдэг үүсмэл хэрэглүүр нь энэ Стандартын дагалдах үүсмэл хэрэглүүрийн шаардлагуудад захирагдана (11-15-р параграфууд болон Хавсралт А-гийн МЗУ40-МЗУ46-р параграфуудыг үзнэ үү).

- (в) УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-ийг мөрдөх ажилтны тэтгэмжийн хөтөлбөрийн дагуу хүлээх ажил олгогчийн эрх ба үүрэг.
- (г) Тухайн байгууллагын гаргасан бөгөөд УСНББОУС 28-д заасан өмчийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангах эсвэл УСНББОУС 28-ын 15, 16-р параграф эсвэл 17, 18-р параграфуудын дагуу өмчийн хэрэглүүр гэж ангилах шаардлагатай санхүүгийн хэрэглүүр (үүн дотроо опцион ба баталгаа). Гэвч санхүүгийн хэрэглүүр нь дээрх (а)-д заасан гажих нөхцлийг хангахаас бусад тохиолдолд ийм өмчийн хэрэглүүрийн эзэмшигч нь тэдгээр хэрэглүүрийн хувьд энэ Стандартыг мөрдөнө.
- (д) Дараах зүйлсээс үүссэн эрх ба үүрэг;
  - (i) 10-р параграфт заасан санхүүгийн баталгааны гэрээний тодорхойлолтыг хангах даатгалын гэрээний дагуу үүсэх, гаргагчийн эрх ба үүргээс бусад даатгалын гэрээ; эсвэл
  - (ii) Сонголттой оролцох шинжийг агуулдаг учраас даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартын цар хүрээнд хамаарах гэрээ.

Даатгалын гэрээг дагалдан гардаг үүсмэл хэрэглүүр нь өөрөө даатгалын гэрээ биш бол уг үүсмэл хэрэглүүрт энэ Стандартыг мөрдөнө (энэ Стандартын 11-15-р параграф болон Хавсралт А-гийн МЗУ40-МЗУ46-р параграфыг үзнэ үү). Байгууллага нь санхүүгийн баталгааны гэрээнд энэ Стандартыг мөрдөх боловч тухайн санхүүгийн баталгааны гэрээг гаргагч нь түүнийг хүлээн зөвшөөрөх ба хэмжихдээ даатгалын гэрээг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг мөрдөх сонголт хийсэн бол тэдгээр стандартыг мөрдөнө. Дээрх (i)-д заасныг үл харгалзан байгууллага нь санхүүгийн эрсдлийн шилжүүлэлтийг агуулсан бусад даатгалын гэрээнд энэ Стандартыг мөрдөж болох юм.

- (е) Худалдан авч буй үйл ажиллагааг худалдан авах буюу худалдах талаар тухайн нэгтгэгч болон борлуулагчийн хооронд байгуулсан бөгөөд тэрхүү ирээдүйн худалдан авалтын өдөр улсын секторын нэгдэл үүсэхэд хүргэх аливаа форвард гэрээ. Форвард гэрээний хугацаа нь аливаа шаардлагатай зөвшөөрлийг олж авах ба тухайн ажил гүйлгээг хэрэгжүүлэхэд хэвийн шаардагдах ул үндэслэлтэй хугацаанаас хэтрэхгүй байвал зохино.
- (ж) 4-р параграфт дурдсан зээл олгох баталгаанаас бусад зээл олгох баталгаа. Гэвч зээл олгох баталгаа гаргагч нь энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй уг зээл олгох баталгааны хувьд УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-ийг мөрдөнө. Гэвч зээл олгох бүх баталгаа нь энэ Стандартын үл хүлээн зөвшөөрөлтийн шаардлагад захирагдана

(17-44-р параграф болон Хавсралт А-гийн МЗУ51-МЗУ80-р параграфыг үзнэ үү).

- (и) Энэ Стандартыг мөрддөг ба түүний 4-6-р параграфын цар хүрээнд хамаарах гэрээнүүдээс бусад бөгөөд хувьцаанд суурилсан төлбөрийг зохицуулдаг олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг мөрддөг хувьцаанд суурилсан төлбөрийн ажил гүйлгээнээс үүссэн санхүүгийн хэрэглүүр, гэрээ, үүрэг.
- (к) УСНББОУС 19-ийн дагуу нөөц гэж хүлээн зөвшөөрөх эсвэл УСНББОУС 19-ийн дагуу өмнөх тайлант үед нөөц гэж хүлээн зөвшөөрсөн өр төлбөрийг барагдуулахад шаардлагатай зарлагын хувьд тухайн байгууллагад нөхөн төлөгдөх төлбөрийг хүлээн авах эрх.
- (л) УСНББОУС 23, *Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Татвар ба Шилжүүлэг)*-ыг мөрдөх арилжааны бус орлогын ажил гүйлгээнээс үүссэн эрх, үүргийн анхны хүлээн зөвшөөрөлт ба анхны хэмжилт.
- (м) УСНББОУС 32, *Үйлчилгээний Концессын Хэлцэл: Эрх бүхий этгээд*-ийг мөрдөх үйлчилгээний концессын хэлцлээс үүссэн эрх ба үүрэг. Гэвч санхүүгийн өр төлбөрийн загварын дагуу уг эрх бүхий этгээдийн хүлээн зөвшөөрөх санхүүгийн өр төлбөр нь энэ Стандартын үл хүлээн зөвшөөрөлтийн шаардлагуудад захирагдана (41-44-р параграф болон Хавсралт А-гийн МЗУ72-МЗУ80-р параграфыг үзнэ үү).

3. Дараах зээл олгох баталгаа нь энэ Стандартын цар хүрээнд хамаарна:

- (а) Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг санхүүгийн өр төлбөр гэж тухайн байгууллагын ангилсан зээл олгох баталгаа. Зээл олгох баталгаанаасаа үүссэн хөрөнгийг түүний бий болсон даруйд худалдан борлуулж байсан өмнөх практик бүхий байгууллага нь тэрхүү зээл олгох баталгааны ангид хамаарах өөрийн бүх зээл олгох баталгааны хувьд энэ Стандартыг мөрдөнө.
- (б) Цэвэр дүнгээр нь мөнгөөр эсвэл бусад санхүүгийн хэрэглүүрийг өгөх буюу гаргах замаар барагдуулж болох зээл олгох баталгаа. Ийм зээл олгох баталгаа нь үүсмэл хэрэглүүр юм. Зээлийг хэсэгчлэн төлдөг (жишээлбэл; барилгын ажлын явцтай уялдуулан хэсэгчлэн төлдөг барилгын моргейжийн зээл) гэдгээс зөвхөн хамааран зээл олгох баталгааг цэвэр дүнгээр барагдуулдаг гэж үзэхгүй.
- (в) Зах зээлийн хүүний түвшнээс бага хүүтэйгээр зээл олгох баталгаа. Ийм зээл олгох баталгаанаас үүсэх өр төлбөрийн дараагийн тайлант үеийн хэмжилтийг 49(г) параграфт тусгайлан заасан.

4. Санхүүгийн бус зүйлийг худалдан авах буюу борлуулах бөгөөд цэвэр дүнгээр нь мөнгөөр буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулах, эсвэл санхүүгийн хэрэглүүрүүдээр солилцож болох гэрээнд энэхүү Стандартыг тэдгээр гэрээ нь өөрөө санхүүгийн хэрэглүүр байсан мэтээр мөрдөнө; харин тухайн байгууллагын хүлээгдэж буй худалдан авалт, борлуулалт буюу ашиглалтын шаардлагуудын дагуу санхүүгийн бус зүйлийг хүлээн авах эсвэл өгөх зорилгоор байгуулсан ба ийм зорилгоор үргэлжлүүлэн эзэмшиж буй гэрээнд энэ Стандартыг мөрдөхгүй.

5. Санхүүгийн бус зүйлийг худалдан авах буюу борлуулах гэрээг цэвэр дүнгээр нь мөнгөөр буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулах эсвэл санхүүгийн хэрэглүүрүүдийг солилцох янз бүрийн арга замууд байдаг. Үүнд:

(а) Цэвэр дүнгээр нь мөнгөөр буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулах, эсвэл санхүүгийн хэрэглүүрүүдийг солилцохыг аль нэг талд зөвшөөрсөн гэрээний нөхцөлтэй тохиолдол;

(б) Цэвэр дүнгээр нь мөнгөөр буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулах, эсвэл санхүүгийн хэрэглүүрүүдийг солилцох боломжит байдлыг тухайн гэрээний нөхцөлд тодорхой заагаагүй боловч уг байгууллага нь ижил төсөөтэй гэрээг цэвэр дүнгээр нь мөнгөөр буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулсан эсвэл санхүүгийн хэрэглүүрүүдийг солилцсон практик туршлагатай тохиолдол (харилцан суутгаж, цэвэр дүн гаргах гэрээг нөгөө талтайгаа байгуулснаар, эсвэл гэрээ хэрэгжих буюу түүний хугацаа дуусахаас өмнө уг гэрээг борлуулснаар);

(в) Ижил төсөөтэй гэрээний хувьд байгууллага нь тухайн хэрэглүүрийг гаргах ба түүний үнийн богино хугацааны хэлбэлзлээс эсвэл дилерийн үнийн зөрүүгээс ашиг олох зорилгоор уг гаргалтаас хойшхи богино хугацааны дотор буцаан борлуулж байсан практик туршлагатай тохиолдол; ба

(г) Тухайн гэрээнд хамаарах санхүүгийн бус зүйлийг мөнгөнд шууд хөрвүүлэх боломжтой тохиолдол.

Тухайн байгууллагын хүлээгдэж буй худалдан авалт, борлуулалт буюу ашиглалтын шаардлагын дагуу санхүүгийн бус зүйлийг хүлээн авах эсвэл өгөх тийм зорилгоор дээрх (б) буюу (в) заалтанд хамаарах гэрээг байгуулаагүй бол уг гэрээ нь энэ Стандартын цар хүрээнд хамаарна. Тухайн байгууллагын хүлээгдэж буй худалдан авалт, борлуулалт буюу ашиглалтын шаардлагын дагуу санхүүгийн бус зүйлийг хүлээн авах эсвэл өгөх зорилгоор гэрээг байгуулсан ба ийм зорилгоор үргэлжлүүлэн эзэмшиж буй эсэх, уг гэрээ нь энэ Стандартын цар хүрээнд хамаарах эсэхийг тодорхойлохын тулд 4-р параграфыг мөрдөх бусад гэрээг үнэлж үзнэ.

6. 5(а) буюу 5(г) параграфын дагуу, цэвэр дүнгээр нь мөнгөөр буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулах эсвэл санхүүгийн хэрэглүүрээр солилцох боломжтой, санхүүгийн бус зүйлийг худалдан авах буюу



борлуулахаар гаргасан опцион нь энэ Стандартын цар хүрээнд хамаарна. Ийм гэрээг тухайн байгууллагын хүлээгдэж буй худалдан авалт, борлуулалт буюу ашиглалтын шаардлагуудын дагуу санхүүгийн бус зүйлийг хүлээн авах эсвэл өгөх зорилгоор байгуулахгүй.

7. [Хассан]

8. [Хассан]

## Тодорхойлолт

9. УСНББОУС 28-д тодорхойлсон нэр томъёог энэ Стандартад УСНББОУС 28-ын 9-р параграфт тусгайлан заасан утгаар ойлгож хэрэглэнэ. УСНББОУС 28 нь дараах нэр томъёог тодорхойлж, эдгээр тодорхойлолтыг хэрэглэх заавар удирдамжаар хангадаг:

- Санхүүгийн хэрэглүүр;
- Санхүүгийн хөрөнгө;
- Санхүүгийн өр төлбөр;
- Өмчийн хэрэглүүр.

10. **Энэ Стандартад дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ:**

### *Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт*

**Үүсмэл хэрэглүүр** гэдэг нь энэ Стандартын цар хүрээнд хамаарах (2-6-р параграфыг үзнэ үү) бөгөөд дараах бүх гурван шинж чанар бүхий санхүүгийн хэрэглүүр буюу бусад гэрээ юм:

- (a) Тохиролцсон хүүний хувь, санхүүгийн хэрэглүүрийн үнэ, бараа бүтээгдэхүүний үнэ, гадаад валютын ханш, үнийн буюу ханшийн индекс, зээлийн зэрэглэл буюу зээлийн индекс, түүнчлэн уг гэрээний аль нэг талд тусгайлан хамаарахгүй санхүүгийн бус хувьсагч гэх мэт бусад хувьсагчдын (зарим үед 'суурь зүйл' гэж нэрлэдэг) өөрчлөлтийн хариу болгон түүний үнэ цэнэ өөрчлөгддөг.
- (б) Анхны цэвэр хөрөнгө оруулалт шаарддаггүй эсвэл зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөнд ижил төсөөтэй хариу үзүүлэхээр хүлээгдэж буй бусад төрлийн гэрээний хувьд шаардлагатай дүнгээс бага хэмжээний анхны цэвэр хөрөнгө оруулалт шаарддаг.
- (в) Ирээдүйн өдөр барагдуулдаг.

**Санхүүгийн хэрэглүүрийн дөрвөн ангиллын тодорхойлолт**

**Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр** гэдэг нь дараах нөхцлүүдийн аль нэгийг хангадаг санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр юм:

- (a) Худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж ангилдаг. Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж ангилна:
- (i) Ойрын хугацаанд худалдан борлуулах эсвэл буцаан худалдан авах зорилготойгоор үндсэндээ олж эзэмшсэн буюу гаргасан;
  - (ii) Анх хүлээн зөвшөөрөх үед, хамтад нь удирдан зохицуулдаг бөгөөд богино хугацаанд ашиг олох зорилготой гэсэн нотолгоо бүхий тодорхой санхүүгийн хэрэглүүрийн багцын нэг хэсэг байх;
  - (iii) Үүсмэл хэрэглүүр байх (санхүүгийн баталгааны гэрээ эсвэл сонгосон ба үр дүнтэй хейжийн хэрэглүүр болох үүсмэл хэрэглүүрээс бусад).
- (б) Анх хүлээн зөвшөөрөх үед тухайн байгууллага нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан. Байгууллага нь зөвхөн 13-р параграфтаар зөвшөөрсөн тохиолдолд эсвэл дараах шалтгааны улмаас ингэж ангилах нь илүү хамааралтай мэдээлэл бий болгох үр дүнтэй тохиолдолд ийм ангиллыг ашиглаж болно:
- (i) Энэ нь хөрөнгө, өр төлбөрийг өөр сууриудаар хэмжсэнээр эсвэл тэдгээрийн олз, гарзыг өөр сууриудаар хүлээн зөвшөөрснөөр үүсэх байсан хэмжилтийн болон хүлээн зөвшөөрөлтийн тууштай бус байдлыг (зарим үед “нягтлан бодох бүртгэлийн уялдаагүй байдал” гэж нэрлэдэг) арилгах буюу мэдэгдэхүйц бууруулдаг; эсвэл
  - (ii) Санхүүгийн хөрөнгүүдийн, санхүүгийн өр төлбөрүүдийн бүлэг эсвэл эдгээрийн аль алины бүлгийг тухайн байгууллагын эрсдлийн удирдлагын болон хөрөнгө оруулалтын баримтжуулсан стратегийн дагуу удирдаж, түүний гүйцэтгэлийг бодит үнэ цэнийн сууриар үнэлдэг бөгөөд тэрхүү бүлгийн талаархи мэдээллийг уг байгууллагын эрх бүхий албан тушаалтанд (УСНББОУС 20, *Холбоотой Талуудын Тодруулга*-д тодорхойлсон), тухайлбал, байгууллагын удирдах зөвлөл ба гүйцэтгэх захиралд дотооддоо танилцуулдаг.

Байгууллага нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн талаар, үүн дотроо эдгээр нөхцлүүдийг хэрхэн хангаж буй

талаар тодруулга хийхийг УСНББОУС 30-ын 11-13-р параграф болон МЗУ4-р параграфтаар шаардсан байдаг. Дээрх (ii)-ын дагуу шалгуур хангах хэрэглүүрүүдийн хувьд ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэсэн ангилал нь тухайн байгууллагын эрсдлийн удирдлагын болон хөрөнгө оруулалтын баримтжуулсан стратегитай хэрхэн нийцэж буй талаархи хүүрнэсэн тайлбарыг уг тодруулгад тусган оруулна.

Идэвхитэй зах зээл дэх зах зээлийн жишиг үнэ байхгүй бөгөөд бодит үнэ цэнийг нь найдвартай<sup>1</sup> хэмжиж чадахгүй, өмчийн хэрэглүүрийн хөрөнгө оруулалтыг (48(в) параграф болон Хавсралт А-гийн МЗУ113, МЗУ114-р параграфуудыг үзнэ үү) ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилахгүй.

Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийн найдвартай хэмжүүрийг тодорхойлох шаардлагуудыг тогтоодог 50, 51, 52-р параграфууд болон Хавсралт А-гийн МЗУ101-МЗУ115-р параграфуудыг бодит үнэ цэнээр хэмжсэн бүх зүйлсэд, тэдгээрийг ингэж ангилсан үгүй эсэх, эсвэл тэдгээрийн бодит үнэ цэнийг тодруулсан эсэхээс үл хамааран мөн адил мөрдөнө гэдгийг анхаарах хэрэгтэй.

Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт гэдэг нь тухайн байгууллага түүнийг дуусгавар хугацаа хүртэл эзэмших эерэг санаа зорилго ба чадвар боломжтой бөгөөд тогтмол буюу тодорхойлж болох төлбөрүүдтэй, тогтоосон дуусгавар болох хугацаатай, доор дурдсанаас бусад, үүсмэл бус санхүүгийн хөрөнгө юм (Хавсралт А-гийн МЗУ29-МЗУ38-р параграфыг үзнэ үү):

- (a) Анх хүлээн зөвшөөрөх үед уг байгууллага нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан санхүүгийн хөрөнгө;
- (б) Байгууллага нь борлуулах боломжтой гэж ангилсан санхүүгийн хөрөнгө; ба
- (в) Зээл ба авлагын тодорхойлолтыг хангадаг санхүүгийн хөрөнгө.

Хэрэв байгууллага нь дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших, мэдэгдэхүйц бус хэмжээнээс илүү дүн (дуусгавар болох хугацаа хүртэл эзэмшиж буй хөрөнгө оруулалтын нийт дүнтэй харьцуулахад мэдэгдэхүйц бус хэмжээнээс илүү дүн) бүхий хөрөнгө оруулалтыг дараах борлуулалт буюу дахин ангиллаас өөр бусад байдлаар түүний дуусгавар болох хугацаанаас өмнө тухайн тайлант жилд болон өмнөх хоёр жилийн хугацаанд борлуулж эсвэл дахин ангилж байсан бол уг

---

<sup>1</sup> Найдвартай мэдээлэл нь материаллаг алдаа ба туйлшралаас ангид байх бөгөөд өөрийн илэрхийлэхээр зориулагдсан буюу илэрхийлнэ гэж үл үндэслэлтэйгээр хүлээж болох зүйлсийг үнэн зөв илэрхийлэхдээ хэрэглэгчдээс хамаардаг байж болох юм. Найдвартай байдлын тайлбарын талаархи шилжилтийн арга хандлагыг УСНББОУС 1-ийн ДҮ16-р параграфт авч хэлэлцсэн.

**байгууллага нь ийм аливаа санхүүгийн хөрөнгийг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмшиж буй гэж ангилахгүй:**

- (а) дуусгавар болох хугацаа буюу тухайн санхүүгийн хөрөнгийн дуудах өдөртэй маш ойрхон (жишээлбэл; дуусгавар болох хугацаа хүртэл гурван сараас богино хугацаатай), ингэснээр хүүний зах зээлийн түвшний өөрчлөлт нь уг санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхээргүй байх;
- (б) Байгууллага нь хуваарьт төлбөрүүд буюу урьдчилсан төлбөрөөр тухайн санхүүгийн хөрөнгийн бараг бүх анхны үндсэн дүнг цуглуулсны дараа хийгдсэн; эсвэл
- (в) Тухайн байгууллагын хяналтанд хамаарахгүй, дахин үл давтагдах ба уг байгууллага ул үндэслэлтэйгээр урьдчилан таамаглаж чадахгүй тусдаа үйл явдалд хамаарах.

**Зээл ба авлага** гэдэг нь идэвхитэй зах зээлд арилжаалдаггүй бөгөөд тогтмол буюу тодорхойлж болох төлбөрүүдтэй доор дурдсанаас бусад, үүсмэл бус санхүүгийн хөрөнгө юм:

- (а) Байгууллага нь нэн даруй эсвэл ойрын хугацаанд худалдан борлуулах санаа төлөвлөгөөтэй бөгөөд худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж ангилах санхүүгийн хөрөнгө ба анх хүлээн зөвшөөрөх үед байгууллага нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан санхүүгийн хөрөнгө;
- (б) Анх хүлээн зөвшөөрөх үед байгууллага нь борлуулах боломжтой гэж ангилсан санхүүгийн хөрөнгө; эсвэл
- (в) Зээлийн чанаргүйдлээс өөр бусад шалтгааны улмаас эзэмшигч нь өөрийн бараг бүх анхны хөрөнгө оруулалтыг нөхөж чадахааргүй болсон бөгөөд борлуулах боломжтой гэж ангилсан санхүүгийн хөрөнгө.

**Зээл буюу авлага биш хөрөнгүүдийн нэгдлээс (жишээлбэл; хамтын сан буюу адилтгах сан дахь хувь оролцооноос) олж эзэмшсэн хувь оролцоо нь зээл эсвэл авлага болохгүй юм.**

**Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө** гэдэг нь (а) зээл ба авлага, (б) дуусгавар болох хугацаа хүртэл эзэмшиж буй хөрөнгө оруулалт, (в) ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө гэж ангилаагүй буюу борлуулах боломжтой гэж ангилсан үүсмэл бус санхүүгийн хөрөнгө юм.

***Санхүүгийн баталгааны гэрээний тодорхойлолт***

**Санхүүгийн баталгааны гэрээ** гэдэг нь өрийн хэрэглүүрийн анхны буюу засварлан өөрчилсөн нөхцлийн дагуу төлөх ёстой төлбөрөө тухайн зээлдэгч барагдуулаагүйн улмаас учирсан алдагдлын хувьд уг

гэрээг эзэмшигчид нөхөн төлбөр болгон тодорхой төлбөр төлөхийг түүний гаргагчаас шаарддаг гэрээ юм.

*Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилттэй холбоотой тодорхойлолт*

Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртөг гэдэг нь санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөх үед хэмжсэн дүнгээс үндсэн төлбөрийн буцаан төлөлтийг хасаж, уг анхны дүн ба дуусгавар болгох дүнгийн хоорондох аливаа зөрүүгээс үр ашигт хүүний аргыг ашиглан тооцсон, хуримтлагдсан хорогдуулгыг нэмэх буюу хасаж, үнэ цэнийн бууралт буюу үл цуглуулагдах байдлын аливаа хасагдуулгыг (шууд эсвэл хасагдуулгын данс ашигласнаар) хассан дүн юм.

Үр ашигт хүүний арга гэдэг нь санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн (санхүүгийн хөрөнгүүд болон санхүүгийн өр төлбөрүүдийн бүлгийн) хорогдуулсан өртгийг тооцоолох ба хүүний орлого буюу хүүний зардлыг холбогдох тайлант үед хуваарилах арга юм. Үр ашигт хүүний хувь гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны туршид буюу тохиромжтой бол үүнээс богино хугацаанд тооцоолсон ирээдүйн мөнгөн төлбөр эсвэл мөнгөн орлогыг тухайн санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн цэвэр дансны үнэ хүртэл яг нарийн дискаунтчилдаг хүүний хувь юм. Үр ашигт хүүний хувийг тооцоолохдоо байгууллага нь тухайн санхүүгийн хэрэглүүрийн гэрээний бүх нөхцлүүдийг (тухайлбал; урьдчилан төлөлт, дуудах опцион ба үүнтэй ижил төсөөтэй опцион) харгалзан үзсэнээр уг хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг тооцоолох боловч ирээдүйн зээлийн алдагдлыг харгалзан үзэхгүй. Гэрээний талуудын хооронд төлсөн эсвэл хүлээн авсан, уг үр ашигт хүүний хувийн салшгүй хэсэг болох бүх хураамж ба оноо (УСНББОУС 9, *Арилжааны Ажил Гүйлгээний Орлого*-ыг үзнэ үү), ажил гүйлгээний зардал, бусад бүх урамшуулал буюу хөнгөлөлт нь энэхүү тооцоололд хамаарна. Ижил төсөөтэй санхүүгийн хэрэглүүрүүдийн бүлгийн мөнгөн гүйлгээ ба тэдгээрийн хүлээгдэж буй хугацааг найдвартай тооцоолж чадна гэсэн урьдчилсан нөхцөлтэй байдаг. Гэвч санхүүгийн хэрэглүүрийн (санхүүгийн хэрэглүүрүүдийн бүлгийн) мөнгөн гүйлгээ эсвэл хүлээгдэж буй хугацааг найдвартай тооцоолох боломжгүй тийм цөөн ховор тохиолдолд байгууллага нь тухайн санхүүгийн хэрэглүүрийн (санхүүгийн хэрэглүүрүүдийн бүлгийн) нийт гэрээний хугацаан дахь уг гэрээний мөнгөн гүйлгээг харгалзан үзнэ.

Үл хүлээн зөвшөөрөлт гэдэг нь өмнө хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг тухайн байгууллагын санхүүгийн байдлын тайлангаас хасах явдал юм.

Ердийн нөхцлөөр худалдан авалт буюу борлуулалт гэдэг нь тухайн хамаарах зах зээл дэх зохицуулалт буюу тогтсон журмаар ерөнхийдөө тогтоодог цаг хугацааны дотор уг хөрөнгийг

нийлүүлэхийг шаарддаг нөхцөл бүхий гэрээний дагуу санхүүгийн хөрөнгийг худалдан авах буюу борлуулах ажиллагаа юм.

Ажил гүйлгээний зардал гэдэг нь санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн олж эзэмшилт, гаргалт, данснаас хасалтанд шууд хамаарах өсөн нэмэгдэх зардал (Хавсралт А-гийн МЗУ26-р параграфыг үзнэ үү) юм. Өсөн нэмэгдэх зардал нь хэрэв байгууллага тухайн санхүүгийн хэрэглүүрийг олж эзэмшээгүй, гаргаагүй, данснаас хасаагүй бол гарахгүй байсан тийм зардал байдаг.

*Хейжийн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тодорхойлолт*

Арилжааны баталгаа гэдэг нь ирээдүйн товлосон өдөр, тогтоосон үнээр, тодорхой хэмжээний нөөцийг солилцох заавал биелүүлэх хэлцэл юм.

Урьдчилан таамагласан ажил гүйлгээ гэдэг нь баталгаа гаргаагүй боловч урьдчилан төсөөлсөн ирээдүйн ажил гүйлгээ юм.

Хейжийн хэрэглүүр гэдэг нь сонгосон хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн эсвэл мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг өөрийн бодит үнэ цэнээр эсвэл мөнгөн гүйлгээгээр нөхөхөөр хүлээгдэж буй, сонгосон үүсмэл хэрэглүүр (зөвхөн гадаад валютын ханшийн өөрчлөлтийн эрсдлийн хейжийн хувьд) эсвэл сонгосон үүсмэл бус санхүүгийн хөрөнгө, үүсмэл бус санхүүгийн өр төлбөр юм (хейжийн хэрэглүүрийн тодорхойлолтыг 81-86-р параграф болон Хавсралт А-гийн МЗУ127-МЗУ130-р параграфт тайлбарласан).

Хейжийн зүйл гэдэг нь (а) өөрийн бодит үнэ цэнийн эсвэл ирээдүйн мөнгөн гүйлгээний өөрчлөлтийн хувьд тухайн байгууллагыг эрсдэлд өртүүлдэг, (б) хейж хийхээр сонгосон тийм хөрөнгө, өр төлбөр, арилжааны баталгаа, хэрэгжих өндөр магадлалтай урьдчилан таамагласан ажил гүйлгээ, гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалт юм (хейжийн зүйлийн тодорхойлолтыг 87-94-р параграф болон Хавсралт А-гийн МЗУ131-МЗУ141-р параграфт тайлбарласан).

Хейжийн үр дүнтэй байдал гэдэг нь хейж хийсэн эрсдэлд хамаарах уг хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн эсвэл мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг тухайн хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн эсвэл мөнгөн гүйлгээний өөрчлөлтөөр нөхөх хэмжээ юм. (Хавсралт А-гийн МЗУ145-МЗУ156-р параграфыг үзнэ үү).

Бусад УСНББОУС-д тодорхойлсон нэр томъёог тэдгээрт тодорхойлсонтой ижил утгаар энэ Стандартад хэрэглэсэн бөгөөд тусдаа хэвлэсэн, *Тодорхойлсон Нэр Томъёоны Тайлбар Толь-д* дахин нийтэлсэн болно.

## Дагалдах үүсмэл хэрэглүүр

11. Дагалдах үүсмэл хэрэглүүр нь холимог (нэгдсэн) хэрэглүүрийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд уг холимог хэрэглүүр нь мөн үүсмэл бус үндсэн гэрээг агуулсан байдаг. Дагалдах үүсмэл хэрэглүүр нь түүний дангаараа байх үетэй ижил төсөөтэй байдлаар тухайн нэгдсэн (холимог) хэрэглүүрийн зарим мөнгөн гүйлгээ хувьсан өөрчлөгдөхөд хүргэдэг. Дагалдах үүсмэл хэрэглүүр нь тохиролцсон хүүний хувь, санхүүгийн хэрэглүүрийн үнэ, бараа бүтээгдэхүүний үнэ, гадаад валютын ханш, үнийн буюу ханшийн индекс, зээлийн зэрэглэл буюу зээлийн индекс, түүнчлэн уг гэрээний аль нэг талд тусгайлан хамаарахгүй санхүүгийн бус хувьсагч гэх мэт бусад хувьсагчдад нийцүүлэн зарим буюу бүх мөнгөн гүйлгээг засварлан өөрчлөх шалтгаан болдог бөгөөд хэрэв ингэж өөрчлөхгүй бол тийм өөрчлөлт хийхийг тухайн гэрээгээр шаардах юм. Санхүүгийн хэрэглүүрийг дагалдан гардаг боловч гэрээний дагуу тухайн санхүүгийн хэрэглүүрээс тусдаа бие даасан байдлаар шилжүүлж болох эсвэл гэрээний өөр оролцогч тал бүхий үүсмэл хэрэглүүр нь дагалдах үүсмэл хэрэглүүр биш, гэхдээ тусдаа санхүүгийн хэрэглүүр мөн юм.
12. **Дагалдах үүсмэл хэрэглүүрийг зөвхөн дараах тохиолдолд үндсэн гэрээнээс салгаж, энэ Стандартын дагуу үүсмэл хэрэглүүр гэж тайлагнана:**
- (a) **Дагалдах үүсмэл хэрэглүүрийн эдийн засгийн шинж чанар ба эрсдэл нь үндсэн гэрээний эдийн засгийн шинж чанар ба эрсдэлтэй нягт холбоотой биш байх (Хавсралт А-гийн МЗУ43 ба МЗУ46-р параграфыг үзнэ үү);**
  - (б) **Дагалдах үүсмэл хэрэглүүртэй ижил нөхцлөөр авч үзсэн тусдаа хэрэглүүр нь үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолтыг хангадаг; ба**
  - (в) **Холимог (нэгдсэн) хэрэглүүрийг түүний бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх байдлаар бодит үнэ цэнээр хэмждэггүй байх (өөрөөр хэлбэл, ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөрийг дагалдаж буй үүсмэл хэрэглүүрийг түүнээс салгахгүй).**
- Дагалдах үүсмэл хэрэглүүрийг салгаж тусгаарладаг тохиолдолд тухайн үндсэн гэрээ нь хэрэв санхүүгийн хэрэглүүр бол энэ Стандартын дагуу, харин санхүүгийн хэрэглүүр биш бол тохиромжтой бусад Стандартуудын дагуу тайлагнана. Дагалдах үүсмэл хэрэглүүрийг санхүүгийн байдлын тайланд тусад нь толилуулах эсэхийг энэ Стандартад авч үзэхгүй.**
13. **Гэрээ нь нэг буюу хэд хэдэн дагалдах үүсмэл хэрэглүүрийг агуулдаг бол 12-р параграфт заасныг үл харгалзан тухайн байгууллага нь доор дурдсанаас бусад тохиолдолд уг холимог (нэгдсэн) гэрээг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж бүхэлд нь ангилж болно:**

- (а) Дагалдах үүсмэл хэрэглүүр нь тухайн гэрээгээр шаардах байсан мөнгөн гүйлгээг мэдэгдэхүйц өөрчилдөггүй; эсвэл
  - (б) Ижил төсөөтэй холимог (нэгдсэн) хэрэглүүрийг анх авч үзэхэд уг дагалдах үүсмэл хэрэглүүрийг салгахыг хориглоно гэдэг нь шинжилгээ хийхгүйгээр эсвэл багахан шинжилгээ хийснээр илт тодорхой байх. Жишээлбэл; зээлийг түүний хорогдуулсан өртөгтэй ойролцоо дүнгээр буцаан төлөхийг тухайн эзэмшигчид зөвшөөрдөг уг зээлийг дагалдсан урьдчилан төлөлтийн опцион.
14. Дагалдах үүсмэл хэрэглүүрийг түүний үндсэн гэрээнээс салгахыг энэ Стандартаар байгууллагаас шаарддаг боловч анх олж эзэмших үед эсвэл дараагийн санхүүгийн тайлагналын үеийн эцэст уг дагалдах үүсмэл хэрэглүүрийг тусад нь хэмжих боломжгүй бол тухайн байгууллага нь тэрхүү холимог (нэгдсэн) гэрээг бүхэлд нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилна. Үүнтэй адилаар, хэрэв байгууллага нь холимог (нэгдсэн) гэрээг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэсэн ангиллаас хасаж, дахин ангилснаар салган тусгаарлах шаардлагатай уг дагалдах үүсмэл хэрэглүүрийг тусад нь хэмжих боломжгүй байвал ийм дахин ангилал хийхийг хориглоно. Энэ тохиолдолд тухайн холимог (нэгдсэн) гэрээг бүхэлд нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан хэвээр байна.
15. Хэрэв байгууллага нь дагалдах үүсмэл хэрэглүүрийн нөхцөл, болзлуудад үндэслэн (жишээлбэл; дагалдах үүсмэл хэрэглүүр нь жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрт үндэслэдэг учраас) түүний бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй байвал уг дагалдах үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнэ нь энэ Стандартын дагуу тодорхойлж чадах тохиолдолд тухайн холимог (нэгдсэн) хэрэглүүрийн бодит үнэ цэнэ ба үндсэн гэрээний бодит үнэ цэнийн зөрүүгээр тодорхойлогдоно. Хэрэв байгууллага нь энэ аргыг ашигласнаар уг дагалдах үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тодорхойлох боломжгүй бол 14-р параграфыг мөрдөх бөгөөд тухайн холимог (нэгдсэн) гэрээг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилна.

## **Хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлт**

### **Анхны хүлээн зөвшөөрөлт**

16. Байгууллага нь тухайн хэрэглүүрийн гэрээний нэг тал болсон зөвхөн тийм тохиолдолд уг байгууллага нь санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг өөрийн санхүүгийн байдлын тайландаа хүлээн зөвшөөрнө (санхүүгийн хөрөнгийн ердийн нөхцлөөр худалдан авалтын хувьд 40-р параграфыг үзнэ үү).

### **Санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлт**

17. Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд 18-25-р параграфууд болон Хавсралт А-гийн МЗУ49-МЗУ67-р параграфуудыг нэгтгэсэн түвшинд мөрдөнө. Иймээс байгууллага нь эхлээд өөрийн хяналтанд буй бүх



байгууллагуудыг УСНББОУС 35-ын дагуу нэгтгэх ба үүний үр дүн болох эдийн засгийн нэгдмэл байгууллагын хувьд 18-25-р параграфууд болон Хавсралт А-гийн МЗУ49-МЗУ67-р параграфуудыг дараа нь мөрдөнө.

18. Үл хүлээн зөвшөөрөлт нь тохиромжтой эсэх, түүнчлэн хэр тохиромжтой гэдгийг 18-25-р параграфын дагуу үнэлэхийн өмнө байгууллага нь эдгээр параграфуудыг санхүүгийн хөрөнгийн тодорхой нэг хэсэгт (буюу ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгүүдийн бүлгийн тодорхой нэг хэсэгт) эсвэл санхүүгийн хөрөнгөнд (буюу ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгүүдийн бүлэгт) бүхэлд нь мөрдөх хэрэгтэй эсэхийг дараах байдлаар тодорхойлно:

(a) Үл хүлээн зөвшөөрөхөөр харгалзан үзэж буй санхүүгийн хөрөнгийн тодорхой нэг хэсэг (буюу ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгүүдийн бүлгийн тодорхой нэг хэсэг) нь дараах гурван нөхцлийн аль нэгийг хангаж байх зөвхөн тийм тохиолдолд уг хэсгийн хувьд 19-25-р параграфуудыг мөрдөнө.

(i) Тухайн хэсэг нь санхүүгийн хөрөнгөөс (буюу ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгүүдийн бүлгээс) олох зөвхөн тусгайлан тодорхойлсон мөнгөн гүйлгээг агуулдаг байх. Тухайлбал; байгууллага нь хүүний СТРИП<sup>2</sup> хийсэн бөгөөд ингэснээр оролцогч нөгөө тал нь өрийн хэрэглүүрийн үндсэн төлбөрийн мөнгөн гүйлгээг биш, харин хүүний мөнгөн гүйлгээг авах эрхтэй болсон. Ийм хүүний мөнгөн гүйлгээний хувьд 19-25-р параграфыг мөрдөнө.

(ii) Тухайн хэсэг нь санхүүгийн хөрөнгөөс (буюу ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгүүдийн бүлгээс) олох мөнгөн гүйлгээтэй шууд хамааралтай (хувь тэнцүүлэн) зөвхөн тэдгээр мөнгөн гүйлгээг агуулдаг байх. Тухайлбал; оролцогч нөгөө тал нь өрийн хэрэглүүрийн бүх мөнгөн гүйлгээний 90 хувийг авах эрхтэй байхаар байгууллага нь хэлцэл хийсэн тохиолдолд тэдгээр мөнгөн гүйлгээний 90 хувьд 19-25-р параграфыг мөрдөнө. Харин нэгээс олон оролцогч талтай үед тухайн шилжүүлж буй байгууллага нь шууд хамаарах хувь хэсгийг эзэмшдэг бол бусад оролцогч тал бүр нь тэдгээр мөнгөн гүйлгээний хувьд заавал хувь тэнцүүлсэн оролцоотой байхыг шаардахгүй.

(iii) Тухайн хэсэг нь санхүүгийн хөрөнгөөс (буюу ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгүүдийн бүлгээс) олох, тусгайлан тодорхойлсон мөнгөн гүйлгээтэй шууд

---

<sup>2</sup> СТРИП буюу STRIPS нь Separate Trading of Registered Interest and Principal of Securities-Үнэт Цаасны Нэрлэсэн Хүү ба Үндсэн Төлбөрийн Тусдаа Арилжаа гэсэн үгийн товчлол юм. Тухайлбал; 10 жилийн хугацаатай, жил бүр 10 хувийн нэрлэсэн хүү төлөх бөгөөд тухайн хугацааны эцэст үндсэн дүнг нэг удаа төлөх 100,000ТН-ийн нэрлэсэн дүнтэй бонд байлаа гэхэд үүнийг салгаж, хоёр буюу хэд хэдэн санхүүгийн хэрэглүүр болгож болно. Жишээлбэл; жил бүр буюу нийт 10 удаа төлөх хүүг нэг санхүүгийн хэрэглүүр, 10 жилийн дараа төлөх үндсэн дүнг өөр нэг санхүүгийн хэрэглүүр гэж үзэж болно. Ред.Ч.Д.

хамааралтай (хувь тэнцүүлэн) зөвхөн тэдгээр мөнгөн гүйлгээг агуулдаг байх. Тухайлбал; оролцогч нөгөө тал нь санхүүгийн хөрөнгийн хүүний мөнгөн гүйлгээний 90 хувийг авах эрхтэй байхаар байууллага нь хэлцэл хийсэн тохиолдолд тэдгээр хүүний мөнгөн гүйлгээний 90 хувьд 19-25-р параграфыг мөрдөнө. Харин нэгээс олон оролцогч талтай үед тухайн шилжүүлж буй байгууллага нь шууд хамаарах хувь хэсгийг эзэмшдэг бол бусад оролцогч тал бүр нь тэдгээр тусгайлан тодорхойлсон мөнгөн гүйлгээний хувьд заавал хувь тэнцүүлсэн оролцоотой байхыг шаардахгүй.

- (б) Бусад бүх тохиолдолд 19-25-р параграфыг санхүүгийн хөрөнгөнд (буюу ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгүүдийн бүлэгт) бүхэлд нь мөрдөнө. Жишээлбэл; байгууллага нь (i) санхүүгийн хөрөнгөөс (буюу ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгүүдийн бүлгээс) цуглуулах мөнгөн орлогын хамгийн эхний эсвэл хамгийн сүүлийн 90 хувийг авах эрхийг шилжүүлсэн, эсвэл (ii) бүлэг авлагаас цуглуулах мөнгөн гүйлгээний 90 хувийг авах эрхийг шилжүүлсэн бөгөөд уг авлагын үндсэн дүнгийн 8 хувь хүртэлх аливаа зээлийн алдагдлын хувьд тухайн авлагын худалдан авагчид нөхөн төлбөр олгох баталгааг гаргасан бол 19-25-р параграфыг тэрхүү санхүүгийн хөрөнгөнд (буюу ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгүүдийн бүлэгт) бүхэлд нь мөрдөнө.

19-25-р параграфуудын хувьд 'санхүүгийн хөрөнгө' гэсэн нэр томъёо нь дээрх (а)-д тодорхойлсон санхүүгийн хөрөнгийн тодорхой нэг хэсэг (буюу ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгүүдийн бүлгийн тодорхой нэг хэсэг)-ийг эсвэл санхүүгийн хөрөнгө (буюу ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгүүдийн бүлэг)-ийг бүхэлд нь илэрхийлнэ.

19. Байгууллага нь зөвхөн дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө:

- (а) Тухайн санхүүгийн хөрөнгөөс бий болох мөнгөн гүйлгээг авах гэрээний эрхийн хүчинтэй хугацаа дууссан буюу хүчингүй болсон; эсвэл
- (б) Байгууллага нь 20, 21-р параграфт заасанчлан, тухайн санхүүгийн хөрөнгийг шилжүүлсэн бөгөөд уг шилжүүлэлт нь 22-р параграфт заасан үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангасан.

(Санхүүгийн хөрөнгийн ердийн нөхцлөөр борлуулалтын хувьд 40-р параграфыг үзнэ үү.)

20. Байгууллага нь зөвхөн дараах хоёр хувилбарын аль нэгээр санхүүгийн хөрөнгийг шилжүүлнэ:

- (а) Тухайн санхүүгийн хөрөнгөөс бий болох мөнгөн гүйлгээг хүлээн авах гэрээний эрхийг шилжүүлэх; эсвэл

- (б) Тухайн санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээг хүлээн авах гэрээний эрхийг хадгалан үлдсэн боловч 21-р параграфт заасан нөхцлийг хангасан хэлцлийн дагуу нэг буюу хэд хэдэн хүлээн авагч талуудад уг мөнгөн гүйлгээг төлөх гэрээний үүргийг хүлээх.
21. Байгууллага нь санхүүгийн хөрөнгө (“анхны хөрөнгө”)-ийн мөнгөн гүйлгээг хүлээн авах гэрээний эрхийг хадгалан үлдсэн боловч нэг буюу хэд хэдэн байгууллагууд (“эцсийн хүлээн авагчид”)-д тэдгээр мөнгөн гүйлгээг төлөх гэрээний үүргийг хүлээсэн бол тухайн байгууллага нь дараах гурван нөхцөл бүгд хангагдсан зөвхөн тийм тохиолдолд уг ажил гүйлгээг санхүүгийн хөрөнгийн шилжүүлэлт гэж үзнэ.
- (а) Байгууллага нь тухайн анхны хөрөнгөөс адилтгах дүнг цуглуулан авахгүй л бол тэдгээр эцсийн хүлээн авагчдад тэрхүү дүнг төлөх үүрэг хүлээхгүй байх. Зээлдүүлсэн дүн, түүнчлэн зах зээлийн түвшнээр хуримтлуулан тооцсон хүүг бүрэн буцаан авах эрхтэйгээр тухайн байгууллагын олгосон богино хугацааны урьдчилгаа нь энэ нөхцлийг зөрчихгүй.
- (б) Байгууллага нь эцсийн хүлээн авагчдад мөнгө төлөх үүргийн хувьд тэдэнд баталгаа болгохоос өөр бусад байдлаар тухайн анхны хөрөнгийг барьцаалах буюу борлуулахыг уг шилжүүлэлтийн гэрээний нөхцлөөр хориглодог байх.
- (в) Байгууллага нь эцсийн хүлээн авагчдын өмнөөс цуглуулсан аливаа мөнгөн гүйлгээг материаллаг хугацаагаар хойшлуулан саатуулахгүйгээр шилжүүлэх үүрэгтэй байх. Түүнчлэн, байгууллага нь мөнгийг цуглуулсан өдөр ба тухайн эцсийн хүлээн авагчдад шилжүүлэх шаардлагатай өдрийн хоорондох энэхүү барагдуулалтын богино хугацаанд мөнгө буюу түүнтэй адилтгах хөрөнгөнд (УСНББОУС 2, *Мөнгөн Гүйлгээний Тайлан*-д тодорхойлсон) хөрөнгө оруулалт хийх, тэрхүү хөрөнгө оруулалтаас олсон хүүний орлогыг мөн уг эцсийн хүлээн авагчдад шилжүүлэн өгөхөөс бусад тохиолдолд ийм мөнгөн гүйлгээгээр дахин хөрөнгө оруулалт хийх эрхгүй байдаг.
22. Байгууллага нь санхүүгийн хөрөнгийг шилжүүлэх (20-р параграфыг үзнэ үү) тохиолдолд тухайн байгууллага нь уг санхүүгийн хөрөнгийн өмчлөлийн эрсдэл болон өгөөжийг ямар хэмжээгээр хадгалан үлдэж байгаа эсэхээ үнэлнэ. Ингэж үнэлэх үед:
- (а) Хэрэв байгууллага нь санхүүгийн хөрөнгийн өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлэх бол тухайн байгууллага нь уг санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрч, тэрхүү шилжүүлэлтээр бий болсон эсвэл хадгалан үлдсэн аливаа эрх, үүргийг хөрөнгө эсвэл өр төлбөр гэж тусад нь хүлээн зөвшөөрнө.

- (б) **Хэрэв байгууллага нь санхүүгийн хөрөнгийн өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалан үлдэх бол тухайн байгууллага нь уг санхүүгийн хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн хэвээр байна.**
- (в) **Хэрэв байгууллага нь санхүүгийн хөрөнгийн өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлдэггүй, мөн хадгалан үлддэггүй бол тухайн байгууллага нь уг санхүүгийн хөрөнгийн хувьд хяналтыг хадгалан үлдсэн эсэхийг тодорхойлно. Энэ тохиолдолд:**
- (i) **Хэрэв байгууллага нь хяналтыг хадгалан үлдээгүй бол тухайн байгууллага нь уг санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрч, тэрхүү шилжүүлэлтээр бий болсон эсвэл хадгалан үлдсэн аливаа эрх, үүргийг хөрөнгө эсвэл өр төлбөр гэж тусад нь хүлээн зөвшөөрнө.**
- (ii) **Хэрэв байгууллага нь хяналтыг хадгалан үлдсэн бол тухайн байгууллага нь уг санхүүгийн хөрөнгөнд өөрийн оролцоотой байгаа тэр хэмжээгээр санхүүгийн хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн хэвээр байна (32-р параграфыг үзнэ үү).**
23. Тухайн шилжүүлсэн хөрөнгийн цэвэр мөнгөн гүйлгээний дүн болон хугацаанд гарах хувьсан өөрчлөлтийн хувьд байгууллагын хүлээх уг шилжүүлэлтийн өмнөх ба дараах эрсдлийг харьцуулснаар эрсдэл, өгөөжийн шилжүүлэлтийг үнэлнэ (22-р параграфыг үзнэ үү). Хэрэв санхүүгийн хөрөнгийн ирээдүйн цэвэр мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэд гарах хувьсан өөрчлөлтийн хувьд байгууллагын хүлээх эрсдэл нь уг шилжүүлэлтийн үр дүнд мэдэгдэхүйц өөрчлөгдөхгүй бол (тухайлбал; байгууллага нь тогтмол үнээр эсвэл тухайн борлуулалтын үнэ дээр зээлдүүлэгчийн өгөөжийг нэмсэн дүнгээр буцаан худалдан авах тийм гэрээний дагуу санхүүгийн хөрөнгийг борлуулсан бол) тухайн байгууллага нь тэрхүү санхүүгийн хөрөнгийн өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалан үлдсэн байна. Хэрэв ийм хувьсан өөрчлөлтийн хувьд байгууллагын хүлээх эрсдэл нь уг санхүүгийн хөрөнгөтэй холбоотой ирээдүйн цэвэр мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэд гарах нийт хувьсан өөрчлөлттэй харьцуулахад мэдэгдэхүйц дүнтэй биш бол (тухайлбал; байгууллага нь санхүүгийн хөрөнгийг буцаан худалдан авах тохиолдолд тэр үеийн бодит үнэ цэнээр түүнийг буцаан худалдан авч болох зөвхөн тийм сонголттойгоор санхүүгийн хөрөнгийг борлуулсан эсвэл хэлэлцэн тохирсон арай том санхүүгийн хөрөнгөөс олох мөнгөн гүйлгээтэй шууд хамааралтай хэсгийг, жишээлбэл, дэд зээлийг шилжүүлсэн ба энэ нь 21-р параграфт заасан нөхцлийг хангах бол) тухайн байгууллага нь тэрхүү санхүүгийн хөрөнгийн өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн гэж үзнэ.
24. Байгууллага нь өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн эсвэл хадгалан үлдсэн эсэх нь ихэвчлэн илт тодорхой байдаг бөгөөд иймээс ямар нэг тооцоолол хийх шаардлагагүй байдаг. Харин зарим тохиолдолд ирээдүйн цэвэр мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийн хувьсан өөрчлөлтийн хувьд байгууллагын хүлээх уг шилжүүлэлтийн өмнөх

ба дараах эрсдлийг тооцоолж, харьцуулан үзэх шаардлагатай байдаг. Одоогийн зах зээлийн хүүний тохирох хувийг дискаунтын хувь болгон ашигласнаар уг тооцоолол ба харьцуулалтыг хийдэг. Гарч тохиолдох илүү их магадлалтай үр дүнгүүдэд арай их хувийн жин өгөх замаар цэвэр мөнгөн гүйлгээний үл үндэслэлтэйгээр боломжит бүх хувьсан өөрчлөлтийг харгалзан үзнэ.

25. Уг шилжүүлсэн хөрөнгийн хувьд байгууллага хяналтыг хадгалан үлдсэн (22(в) параграфыг үзнэ үү) эсэх нь тухайн хөрөнгийг шилжүүлэн авч буй тал түүнийг борлуулах чадвар боломжоос хамаардаг. Хэрэв шилжүүлэн авч буй тал нь харилцан холбоогүй гуравдагч этгээдэд уг хөрөнгийг бүхэлд нь худалдан борлуулах чадвар боломжтой бөгөөд тухайн шилжүүлэлтийн хувьд нэмэлт хязгаарлалт тавихгүйгээр тэрхүү өөрийн чадварыг дангаараа хэрэгжүүлэх боломжтой бол байгууллага нь хяналтыг хадгалан үлдээгүй гэж үзнэ. Бусад бүх тохиолдолд байгууллага нь хяналтыг хадгалан үлдсэн хэвээр байна.

*Үл хүлээн зөвшөөрөх шалгуур хангах шилжүүлэлт (22(а) ба (в)(i) параграфыг үзнэ үү)*

26. Санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангах тийм шилжүүлэлтээр тухайн байгууллага нь санхүүгийн хөрөнгийг шилжүүлсэн бөгөөд уг санхүүгийн хөрөнгөнд төлбөртэй үйлчилгээ үзүүлэх эрхийг өөрөө хадгалж үлдсэн бол байгууллага нь тэрхүү үйлчилгээний гэрээний хувьд үйлчилгээний хөрөнгө эсвэл үйлчилгээний өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Хэрэв хүлээн авах үйлчилгээний хураамж нь тухайн үйлчилгээнд хамаарах зохих нөхөн төлбөрөөс бага байхаар хүлээгдэж байвал тэрхүү үйлчилгээний үүргийн хувьд үйлчилгээний өр төлбөрийг түүний бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрнө. Хэрэв хүлээн авах үйлчилгээний хураамж нь тухайн үйлчилгээнд хамаарах зохих нөхөн төлбөрөөс илүү байхаар хүлээгдэж байвал 29-р параграфт заасан, арай том санхүүгийн хөрөнгийн дансны үнийн хуваарилалтанд үндэслэн тодорхойлсон дүнгээр уг үйлчилгээний эрхийн хувьд үйлчилгээний хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.
27. Шилжүүлэлтийн үр дүнд санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь үл хүлээн зөвшөөрсөн боловч тэрхүү шилжүүлэлт нь уг байгууллагыг шинэ санхүүгийн хөрөнгө олж эзэмших эсвэл шинэ санхүүгийн өр төлбөр болон үйлчилгээний өр төлбөрийг хариуцахад хүргэж байвал байгууллага нь тухайн шинэ санхүүгийн хөрөнгө, шинэ санхүүгийн өр төлбөр буюу үйлчилгээний өр төлбөрийг тэдгээрийн бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрнө.
28. Санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь үл хүлээн зөвшөөрөх тохиолдолд дараах дүнгүүдийн хоорондох зөрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө:

(а) Дансны үнэ; ба

- (б) Доорх дүнгүүдийн нийлбэр. Үүнд: (i) хүлээн авсан төлбөр (үүн дотроо, олж эзэмшсэн аливаа шинэ хөрөнгөөс уг хариуцсан аливаа шинэ өр төлбөрийг хассан дүн) ба (ii) цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн аливаа хуримтлагдсан олз буюу гарз (64(б) параграфыг үзнэ үү).

29. Шилжүүлсэн хөрөнгө нь арай том санхүүгийн хөрөнгийн нэг хэсэг (жишээлбэл; байгууллага нь өрийн хэрэглүүрийн нэг хэсэг болох хүүний мөнгөн гүйлгээг шилжүүлсэн, 18(а) параграфыг үзнэ үү) бөгөөд энэхүү шилжүүлсэн хэсэг нь түүнийг бүхэлд нь үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж байвал тухайн арай том санхүүгийн хөрөнгийн өмнөх дансны үнийг уг хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа хэсэг болон үл хүлээн зөвшөөрсөн хэсэгт тэрхүү шилжүүлэлтийн өдрөөрх тэдгээрийн харгалзах бодит үнэ цэнэд үндэслэн хуваарилна. Хадгалан үлдсэн үйлчилгээний хөрөнгийг энэхүү зорилгын хувьд хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа хэсэг гэж үзнэ. Дараах дүнгүүдийн хоорондох зөрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө:

- (а) Үл хүлээн зөвшөөрсөн хэсэгт хуваарилсан дансны үнэ; ба
- (б) Доорх дүнгүүдийн нийлбэр. Үүнд: (i) үл хүлээн зөвшөөрсөн хэсгийн хувьд хүлээн авсан төлбөр (үүн дотроо, олж эзэмшсэн аливаа шинэ хөрөнгөөс уг хариуцсан аливаа шинэ өр төлбөрийг хассан дүн) ба (ii) цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн аливаа хуримтлагдсан олз буюу гарз (64(б) параграфыг үзнэ үү).

Цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн, хуримтлагдсан олз буюу гарзыг тухайн хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа хэсэг болон үл хүлээн зөвшөөрсөн хэсэгт тэдгээрийн харгалзах бодит үнэ цэнэд үндэслэн хуваарилна.

30. Байгууллага нь уг арай том санхүүгийн хөрөнгийн өмнөх дансны үнийг тухайн хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа хэсэг ба үл хүлээн зөвшөөрсөн хэсэгт хуваарилах тохиолдолд тэрхүү хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа хэсгийн бодит үнэ цэнийг тодорхойлох шаардлагатай байдаг. Байгууллага нь уг хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа хэсэгтэй ижил төсөөтэй тийм хэсгүүдийг өмнө нь борлуулж байсан түүхэн туршлагатай эсвэл тийм хэсгүүдэд хамаарах зах зээлийн бусад ажил гүйлгээ байгаа бол тэдгээр бодит ажил гүйлгээний сүүлийн үеийн үнэ нь түүний бодит үнэ цэнийн хамгийн сайн тооцоолол болдог. Хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа хэсгийн бодит үнэ цэнийг дэмжин нотлох зах зээлийн жишиг үнэ байхгүй эсвэл сүүлийн үеийн зах зээлийн ажил гүйлгээ гарч тохиолдоогүй бол тэрхүү арай том санхүүгийн хөрөнгөнд бүхэлдээ хамаарах бодит үнэ цэнэ ба тухайн үл хүлээн зөвшөөрсөн хэсгийн хувьд шилжүүлэн авагчаас хүлээн авсан төлбөрийн хоорондох зөрүү нь бодит үнэ цэнийн хамгийн сайн тооцоолол болно.

*Үл хүлээн зөвшөөрөх шалгуур хангахгүй шилжүүлэлт (22(б) параграфыг үзнэ үү)*

31. Байгууллага нь шилжүүлсэн хөрөнгийн өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалан үлддэг учраас шилжүүлэлт нь үл хүлээн

зөвшөөрөлтөнд хүргэдэггүй бол тухайн байгууллага нь уг шилжүүлсэн хөрөнгийг бүхэлд нь хүлээн зөвшөөрсөн хэвээр байх бөгөөд хүлээн авсан төлбөрийн хувьд санхүүгийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Байгууллага нь дараагийн тайлант үеүдэд уг шилжүүлсэн хөрөнгийн хувьд үүссэн аливаа орлого ба тухайн санхүүгийн өр төлбөрийн хувьд гарсан аливаа зардлыг хүлээн зөвшөөрнө.

*Шилжүүлсэн хөрөнгө дэх цаашдын оролцоо (22(в)(ii) параграфыг үзнэ үү)*

32. Хэрэв байгууллага нь санхүүгийн хөрөнгийн өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлдэггүй, мөн хадгалан үлддэггүй бөгөөд уг шилжүүлсэн хөрөнгийн хувьд хяналтыг хадгалан үлддэг бол тухайн байгууллага нь өөрийн цаашдын оролцооны хэмжээгээр тэрхүү шилжүүлсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн хэвээр байна. Шилжүүлсэн хөрөнгө дэх тухайн байгууллагын цаашдын оролцооны хэмжээ нь уг шилжүүлсэн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтийн хувьд эрсдэл хүлээх хэмжээ юм. Тухайлбал:
- (a) Байгууллагын цаашдын оролцоо нь уг шилжүүлсэн хөрөнгөнд гаргасан баталгаа хэлбэртэй байх тохиолдолд тухайн байгууллагын цаашдын оролцооны хэмжээ нь дараах дүнгүүдийн аль бага байх юм. Үүнд: (i) хөрөнгийн дүн, (ii) хүлээн авсан төлбөрөөс буцаан төлөхийг тухайн байгууллагаас шаардаж болох хамгийн их дүн (“баталгааны дүн”).
  - (б) Байгууллагын цаашдын оролцоо нь уг шилжүүлсэн хөрөнгийн хувьд гаргасан эсвэл худалдан авсан опцион хэлбэртэй (эсвэл гаргасан ба худалдан авсан опцион хоёулаа байх) байх тохиолдолд байгууллагын цаашдын оролцооны хэмжээ нь түүний буцаан худалдан авч болох тухайн шилжүүлсэн хөрөнгийн дүнтэй тэнцүү байна. Гэвч энэ нь уг хөрөнгийн хувьд гаргасан ба бодит үнэ цэнээр хэмжсэн, буцаах эрхтэй опцион байх тохиолдолд тухайн байгууллагын цаашдын оролцооны хэмжээ нь тэрхүү шилжүүлсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ ба опционы хэрэгжих үнийн аль багаар хязгаарлагдана (МЗУ63-р параграфыг үзнэ үү).
  - (в) Байгууллагын цаашдын оролцоо нь уг шилжүүлсэн хөрөнгийн хувьд гаргасан бөгөөд мөнгөөр төлөгдөх опцион буюу үүнтэй ижил төсөөтэй нөхцөл хэлбэртэй байх тохиолдолд байгууллагын цаашдын оролцоог дээрх (б)-д заасан мөнгөөр төлөгдөхгүй опционы үр дагавартай ижил арга замаар хэмжинэ.
33. Байгууллага нь өөрийн цаашдын оролцооны хэмжээгээр хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн хэвээр байх тохиолдолд тухайн байгууллага нь холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрсөн хэвээр байна. Уг шилжүүлсэн хөрөнгө болон холбогдох өр төлбөрийг тухайн байгууллагын хадгалан үлдсэн эрх, үүргийг тусгах тийм сууриар энэ Стандарт дахь хэмжилтийн бусад шаардлагуудыг үл харгалзан

хэмжинэ. Шилжүүлсэн хөрөнгө болон холбогдох өр төлбөрийн цэвэр дансны үнэ нь дараах дүнгийн аль нэг байх тийм байдлаар уг холбогдох өр төлбөрийг хэмжинэ:

- (a) Хэрэв шилжүүлсэн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр хэмждэг бол тухайн байгууллагын хадгалан үлдсэн эрх, үүргийн хорогдуулсан өртөг; эсвэл
- (б) Хэрэв шилжүүлсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмждэг бол тухайн байгууллагын хадгалан үлдсэн эрх, үүргийг тус тусад нь хэмжих үед тэдгээрийн бодит үнэ цэнэтэй тэнцүү дүн.

34. Байгууллага нь уг шилжүүлсэн хөрөнгөөс үүсэх аливаа орлогыг түүний цаашдын оролцооны хэмжээгээр хүлээн зөвшөөрсөн хэвээр байх бөгөөд холбогдох өр төлбөрийн хувьд гарсан аливаа зардлыг хүлээн зөвшөөрнө.

35. Дараагийн тайлант үеийн хэмжилтийн зорилгоор, уг шилжүүлсэн хөрөнгө болон холбогдох өр төлбөрийн бодит үнэ цэнэд гарсан, хүлээн зөвшөөрсөн өөрчлөлтүүдийг 64-р параграфын дагуу аль алины хувьд тууштай тайлагнах бөгөөд харилцан суутгаж, цэвэр дүнгээр бүртгэхгүй.

36. Хэрэв байгууллагын цаашдын оролцоо нь санхүүгийн хөрөнгийн зөвхөн нэг хэсэгт хамаарах (жишээлбэл; байгууллага нь шилжүүлсэн хөрөнгийн тухайн хэсгийг буцаан худалдан авах сонголтыг хадгалж үлдсэн, эсвэл өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалан үлдэхэд хүргэхгүй тийм үлдэх хувь оролцоог хадгалан үлдсэн боловч уг байгууллага нь хяналтыг хадгалан үлдсэн) бол байгууллага нь уг санхүүгийн хөрөнгийн өмнөх дансны үнийг цаашдын оролцооны дагуу хүлээн зөвшөөрсөн хэвээр байх хэсэг болон цаашид хүлээн зөвшөөрөхгүй хэсэгт тэрхүү шилжүүлэлтийн өдрөөрх тухайн хэсгүүдийн харгалзах бодит үнэ цэнэд үндэслэн хуваарилна. Энэ зорилгын хувьд 30-р параграфын шаардлагуудыг мөрдөнө. Дараах дүнгүүдийн хоорондох зөрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө:

- (a) Цаашид хүлээн зөвшөөрөхгүй тухайн хэсэгт хуваарилсан дансны үнэ; ба
- (б) Доорх дүнгүүдийн нийлбэр. Үүнд: (i) цаашид хүлээн зөвшөөрөхгүй хэсгийн хувьд хүлээн авсан төлбөр ба (ii) цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн аливаа хуримтлагдсан олз буюу гарз (64(б) параграфыг үзнэ үү).

Цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн, хуримтлагдсан олз буюу гарзыг тухайн хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа хэсэг болон цаашид хүлээн зөвшөөрөхгүй хэсэгт тэдгээрийн харгалзах бодит үнэ цэнэд үндэслэн хуваарилна.

37. Хэрэв шилжүүлсэн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр хэмжсэн бол санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр



хэмжсэн гэж ангилах энэ Стандартад заасан сонголт нь уг холбогдох өр төлбөрийн хувьд хамаарахгүй.

*Бүх шилжүүлэлт*

38. Хэрэв шилжүүлсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн хэвээр байвал уг хөрөнгө болон холбогдох өр төлбөрийг харилцан суутгаж, цэвэр дүнг гаргахгүй. Үүнтэй адилаар, байгууллага нь уг шилжүүлсэн хөрөнгөөс бий болсон аливаа орлогыг тухайн холбогдох өр төлбөрийн хувьд гарсан аливаа зардалтай харилцан суутгаж, цэвэр дүнг гаргахгүй (УСНББОУС 28-ын 47-р параграфыг үзнэ үү).
39. Хэрэв шилжүүлэгч нь тухайн шилжүүлэн авагчид мөнгөн бус барьцаа (өрийн буюу өмчийн хэрэглүүр гэх мэт) өгсөн бол тэрхүү барьцааг бүртгэх шилжүүлэгч ба шилжүүлэн авагчийн нягтлан бодох бүртгэл нь шилжүүлэн авагч барьцааг борлуулах буюу бусдад барьцаалах эрхтэй эсэх, шилжүүлэгч үүргээ үл биелүүлсэн эсэхээс хамаарна. Шилжүүлэгч ба шилжүүлэн авагч нь уг барьцааг дараах байдлаар тайлагнана:
- (а) Хэрэв шилжүүлэн авагч нь уг барьцааг борлуулах буюу бусдад барьцаалах талаар гэрээнд заасан эрхтэй эсвэл ийм хэвшин тогтсон практиктай бол шилжүүлэгч нь тухайн хөрөнгийг өөрийн санхүүгийн байдлын тайландаа бусад хөрөнгөөс тусад нь салгаж, (жишээлбэл; зээлдүүлсэн хөрөнгө, барьцаалсан өмчийн хэрэглүүр эсвэл буцаан худалдан авах авлага гэх мэтээр) дахин ангилна.
  - (б) Хэрэв шилжүүлэн авагч нь түүнд барьцаалсан барьцааны зүйлийг борлуулсан бол тэрээр уг борлуулалтын орлого, түүнчлэн тухайн барьцааг буцаан өгөх өөрийн үүргийн хувьд бодит үнэ цэнээр хэмжсэн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.
  - (в) Хэрэв шилжүүлэгч нь гэрээний дагуу үүргээ биелүүлээгүй бөгөөд барьцаагаа буцаан авах эрхгүй болсон бол тухайн шилжүүлэгч нь барьцааны зүйлийг үл хүлээн зөвшөөрөх ба шилжүүлэн авагч нь уг барьцааны зүйлийг түүний бодит үнэ цэнээр анх хэмжиж, хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө, харин барьцааны зүйлийг аль хэдийн борлуулсан бол тухайн барьцааны зүйлийг буцаан өгөх өөрийн үүргийг үл хүлээн зөвшөөрнө.
  - (г) Дээрх (в)-д зааснаас бусад тохиолдолд шилжүүлэгч нь уг барьцааг өөрөө хөрөнгө гэж бүртгэсэн хэвээр байх бөгөөд шилжүүлэн авагч нь тухайн барьцааг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхгүй.

**Санхүүгийн хөрөнгийн ердийн нөхцлөөр худалдан авалт буюу борлуулалт**

40. Санхүүгийн хөрөнгийн ердийн нөхцлөөр худалдан авалт буюу борлуулалтыг арилжааны өдрийн нягтлан бодох бүртгэл эсвэл

барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийн аль тохиромжтойг ашигласнаар хүлээн зөвшөөрөх буюу үл хүлээн зөвшөөрнө (Хавсралт А-гийн МЗУ68-МЗУ71-р параграфыг үзнэ үү).

#### Санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт

41. Байгууллага нь санхүүгийн өр төлбөрийг (буюу түүний нэг хэсгийг) зөвхөн дуусгавар болгосон үед, өөрөөр хэлбэл гэрээнд тусгайлан заасан үүргийг биелүүлсэн эсвэл чөлөөлсөн, цуцалсан, хугацаа дууссан үед өөрийн санхүүгийн байдлын тайлангаас хасна.
42. Өрийн хэрэглүүрийн одоогийн зээлдэгч ба зээлдүүлэгчийн хооронд мэдэгдэхүйц өөр нөхцлөөр хийсэн солилцоог уг анхны санхүүгийн өр төлбөрийн барагдуулалт ба шинэ санхүүгийн өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт байдлаар тайлагнана. Үүнтэй адилаар, одоогийн санхүүгийн өр төлбөрийн буюу түүний нэг хэсгийн нөхцөлд оруулсан мэдэгдэхүйц өөрчлөлтийг (тухайн зээлдэгчийн санхүүгийн хүндрэлтэй байдалтай холбоотой эсэхээс үл хамааран) уг анхны санхүүгийн өр төлбөрийн барагдуулалт ба шинэ санхүүгийн өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт байдлаар тайлагнана.
43. Барагдуулсан буюу бусад талд шилжүүлсэн санхүүгийн өр төлбөрийн (буюу түүний нэг хэсгийн) дансны үнэ ба төлсөн төлбөрийн (үүн дотроо, шилжүүлсэн аливаа мөнгөн бус хөрөнгө буюу хариуцсан өр төлбөрийн) хоорондох зөрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Зээлдүүлэгч нь үүргээс чөлөөлсөн эсвэл арилжааны бус ажил гүйлгээний нэг хэсэг байдлаар уг үүргийг гуравдагч тал хариуцсан тохиолдолд байгууллага нь УСНББОУС 23-ыг дагаж мөрдөнө.
44. Хэрэв байгууллага нь санхүүгийн өр төлбөрийн нэг хэсгийг буцаан худалдан авсан бол байгууллага нь тэрхүү санхүүгийн өр төлбөрийн өмнөх дансны үнийг уг хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа хэсэг болон үл хүлээн зөвшөөрсөн хэсэгт тухайн буцаан худалдан авалтын өдрөөрх тэдгээрийн харгалзах бодит үнэ цэнэд үндэслэн хуваарилна. (а) үл хүлээн зөвшөөрсөн хэсэгт хуваарилсан дансны үнэ, ба (б) уг үл хүлээн зөвшөөрсөн хэсгийн хувьд төлсөн төлбөр, үүн дотроо шилжүүлсэн аливаа мөнгөн бус хөрөнгө буюу хариуцсан өр төлбөрийн хоорондох зөрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

#### Хэмжилт

##### Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн анхны хэмжилт

45. Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөх үед байгууллага нь түүний бодит үнэ цэнээр хэмжинэ, харин ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжээгүй санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр байх тохиолдолд тэдгээрийн олж эзэмшилт буюу гаргалтанд шууд хамаарах ажил

**гүйлгээний зардлыг тэрхүү дүн дээр нэмэх эсвэл хасах байдлаар хэмжинэ.**

46. Дараагийн тайлант үеүдэд өртөг эсвэл хорогдуулсан өртгөөр хэмжих хөрөнгийн хувьд байгууллага нь барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэдэг тохиолдолд уг хөрөнгийг тухайн арилжааны өдрөөрх түүний бодит үнэ цэнээр анх хүлээн зөвшөөрнө (Хавсралт А-гийн МЗУ68-МЗУ71-р параграфыг үзнэ үү).

#### **Санхүүгийн хөрөнгийн дараагийн тайлант үеийн хэмжилт**

47. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа санхүүгийн хөрөнгийг хэмжих зорилгын хувьд энэ Стандарт нь 10-р параграфт тодорхойлсон доорх дөрвөн ангиллын дагуу санхүүгийн хөрөнгийг ангилдаг:

- (а) Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө;
- (б) Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт;
- (в) Зээл ба авлага;
- (г) Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө.

Энэ Стандартын дагуу хийх хэмжилт болон ашиг, алдагдлын хүлээн зөвшөөрөлтөнд эдгээр ангиллуудыг ашиглана. Байгууллага нь санхүүгийн тайланд мэдээллийг толилуулахдаа эдгээр ангиллын хувьд өөр нэрийг эсвэл өөр ангиллыг ашиглаж болох юм. Байгууллага нь УСНББОУС 30-аар шаардсан мэдээллийг тодруулга хэсэгт толилуулна.

48. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, байгууллага нь доор дурдсанаас бусад, санхүүгийн хөрөнгийг, үүн дотроо хөрөнгө болох үүсмэл хэрэглүүрийг тэдгээрийн бодит үнэ цэнээр хэмжих бөгөөд тухайн хөрөнгийг борлуулах буюу бусад байдлаар данснаас хасахад гарч болох ажил гүйлгээний зардлын хувьд аливаа хасалт хийхгүй:

- (а) 10-р параграфт тодорхойлсон бөгөөд үр ашигт хүүний аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмждэг зээл ба авлага;
- (б) 10-р параграфт тодорхойлсон бөгөөд үр ашигт хүүний аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмждэг, дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт;
- (в) Идэвхитэй зах зээл дэх жишиг зах зээлийн үнэ байхгүй бөгөөд бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжиж чадахгүй, иймээс өртгөөр хэмждэг тийм өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт болон ийм жишиг зах зээлийн үнэгүй өмчийн хэрэглүүртэй холбоотой ба түүнийг өгснөөр барагдуулах ёстой үүсмэл хэрэглүүр (Хавсралт А-гийн МЗУ113, МЗУ114-р параграфуудыг үзнэ үү).

**Хейжийн зүйл гэж сонгосон санхүүгийн хөрөнгийг 99-113-р параграф дахь хейжийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудын дагуу**

хэмжинэ. Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэнээс бусад, бүх санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг 67-79-р параграф болон Хавсралт А-гийн МЗУ117-МЗУ126-р параграфын дагуу няталж шалгана.

**Санхүүгийн өр төлбөрийн дараагийн тайлант үеийн хэмжилт**

49. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, байгууллага нь доор дурдсанаас бусад, бүх санхүүгийн өр төлбөрийг үр ашигт хүүний арга ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжинэ:

- (a) Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөр. Бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжиж чадахгүй, иймээс өртгөөр хэмждэг жишиг зах зээлийн үнэгүй өмчийн хэрэглүүртэй холбоотой ба түүнийг өгснөөр барагдуулах ёстой үүсмэл өр төлбөрөөс бусад, ийм өр төлбөр, үүн дотроо өр төлбөр болох үүсмэл хэрэглүүрийг бодит үнэ цэнээр хэмжинэ.
- (б) Санхүүгийн хөрөнгийн шилжүүлэлт нь үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангадаггүй тохиолдолд эсвэл цаашдын оролцооны хандлагыг хэрэглэх үед үүсдэг санхүүгийн өр төлбөр. Ийм санхүүгийн өр төлбөрийн хэмжилтэнд 31 ба 33-р параграфыг мөрдөнө.
- (в) 10-р параграфт тодорхойлсон санхүүгийн баталгааны гэрээ. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, ийм гэрээг гаргагч нь (49(а) эсвэл (б) параграфыг мөрдөхөөс бусад тохиолдолд) түүнийг доорх дүнгүүдийн аль өндрөөр хэмжинэ:
  - (i) УСНББОУС 19-ийн дагуу тодорхойлсон дүн; ба
  - (ii) Анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс (45-р параграфыг үзнэ үү) хэрэв байгаа бол УСНББОУС 9-ийн дагуу хүлээн зөвшөөрсөн, хуримтлагдсан хорогдуулгыг хассан дүн.
- (г) Зах зээлийн хүүний түвшнээс бага хүүтэйгээр зээл олгох баталгаа. Ийм баталгааг гаргагч нь анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, түүнийг (49(а) параграфыг мөрдсөнөөс бусад тохиолдолд) доорх дүнгүүдийн аль өндрөөр хэмжинэ:
  - (i) УСНББОУС 19-ийн дагуу тодорхойлсон дүн, ба
  - (ii) Анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс (45-р параграфыг үзнэ үү) хэрэв байгаа бол УСНББОУС 19-ийн дагуу хүлээн зөвшөөрсөн, хуримтлагдсан хорогдуулгыг хассан дүн.

Хейжийн зүйл гэж сонгосон санхүүгийн өр төлбөрийг 99-113-р параграф дахь хейжийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудын дагуу хэмжинэ.

**Бодит үнэ цэнийн хэмжилтийн анхаарах зүйлс**

50. **Энэ Стандарт, УСНББОУС 28, УСНББОУС 30-ыг мөрдөх зорилгоор санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо байгууллага нь Хавсралт А-гийн МЗУ101-МЗУ115-р параграфыг мөрдөнө.**
51. Бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо нь идэвхитэй зах зээл дэх жишиг үнэ юм. Хэрэв санхүүгийн хэрэглүүрийн зах зээл нь идэвхитэй биш бол байгууллага нь үнэлгээний арга зүйг ашигласнаар бодит үнэ цэнийг тогтооно. Үнэлгээний арга зүйг ашиглах зорилго нь хэвийн үйл ажиллагааны нөхцлөөр харилцан хамааралгүй талуудын хооронд хийгдэх ажил гүйлгээний үнийг уг хэмжилтийн өдрөөр тодорхойлох явдал байдаг. Зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хоорондох харилцан хамааралгүй зах зээлийн ажил гүйлгээ, хэрэв байгаа бол бараг ижил, бусад хэрэглүүрийн одоогийн бодит үнэ цэнийн лавлагаа, дискаунтчилсан мөнгөн гүйлгээний шинжилгээ, опционы үнэ тогтоох загвар ашиглалт нь үнэлгээний арга зүйд хамаардаг. Хэрэглүүрийн үнийг тогтоохын тулд зах зээлийн оролцогчдын нийтлэг ашигладаг үнэлгээний арга зүй байдаг бөгөөд уг арга зүй нь зах зээлийн бодит ажил гүйлгээгээр олж авсан үнийн талаархи найдвартай тооцооллоор хангана гэдгийг харуулж байвал байгууллага нь тэрхүү арга зүйг ашиглана. Сонгосон үнэлгээний арга зүй нь зах зээлийн орцыг хамгийн ихээр ашиглах бөгөөд байгууллагын тусгайлсан орцод аль болох бага тулгуурладаг. Энэ нь үнэ тогтоохдоо тухайн зах зээлийн оролцогчдын харгалзан үзэх бүх хүчин зүйлсийг нэгтгэн тусгадаг бөгөөд санхүүгийн хэрэглүүрийн үнэ тогтоох эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдсөн арга зүйтэй нийцсэн байдаг. Байгууллага нь тухайн үнэлгээний арга зүйг үечлэн шалгах ба тухайн хэрэглүүрийн хувьд ажиглаж болох аливаа одоогийн зах зээлийн ажил гүйлгээнээс авсан үнийг (өөрөөр хэлбэл, засвар өөрчлөлт хийх буюу дахин нэгтгэн багцлахгүйгээр) ашиглах эсвэл бэлэн боломжтой байгаа, ажиглаж болох зах зээлийн аливаа мэдээнд тулгуурлахын хүчин төгөлдөр байдлыг сорьж шалгадаг.
52. Хугацаагүй шинжтэй санхүүгийн өр төлбөр (жишээлбэл; хугацаагүй хадгаламж)-ийн бодит үнэ цэнэ нь тухайн дүнг төлөхийг шаардаж болох анхны өдрөөс эхлэн дискаунтчилсан, шаардлагын дагуу төлөх дүнгээс багагүй байна.

**Дахин ангилал**

53. **Байгууллага нь:**
- (а) **үүсмэл хэрэглүүрийг эзэмшиж байх эсвэл гаргах үедээ түүнийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг гэсэн ангиллаас хасаж, дахин ангилахгүй;**
  - (б) **хэрэв анх хүлээн зөвшөөрөх үедээ ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан бол аливаа санхүүгийн**

**хэрэглүүрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих уг ангиллаас хасаж, дахин ангилахгүй; ба**

- (в) **хэрэв санхүүгийн хөрөнгийг ойрын хугацаанд борлуулах буюу буцаан худалдан авах зорилгоор цаашид эзэмшихээ больсон бол (тэрхүү санхүүгийн хөрөнгийг ойрын хугацаанд борлуулах буюу буцаан худалдан авах зорилгоор үндсэндээ олж эзэмшсэн эсвэл өгсөн гэдгээс үл хамааран) 55-р эсвэл 57-р параграфын шаардлагууд хангагдаж байх тохиолдолд тухайн санхүүгийн хөрөнгийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэсэн ангиллаас хасаж, дахин ангилж болно.**

**Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа байгууллага нь аливаа санхүүгийн хөрөнгийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэсэн ангилалд оруулж, дахин ангилахгүй.**

54. Нөхцөл байдлын дараах өөрчлөлтүүдийг 53-р параграфын зорилгын хувьд дахин ангилал гэж үзэхгүй:
- (а) Мөнгөн гүйлгээний хейж эсвэл цэвэр хөрөнгө оруулалтын хейжийн хувьд өмнө нь сонгосон ба үр дүнтэй хейжийн хэрэглүүр байсан үүсмэл хэрэглүүр нь ийм шинж чанаргүй болох; ба
- (б) Тухайн үүсмэл хэрэглүүр нь мөнгөн гүйлгээний хейж эсвэл цэвэр хөрөнгө оруулалтын хейжийн хувьд сонгосон ба үр дүнтэй хейжийн хэрэглүүр болох.
55. 53(в) параграфыг мөрддөг санхүүгийн хөрөнгийг (57-р параграфт зааснаас бусад төрлийн санхүүгийн хөрөнгийг) маш цөөн тохиолдолд ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэсэн ангиллаас хасаж, дахин ангилж болно.
56. Хэрэв байгууллага нь 55-р параграфын дагуу санхүүгийн хөрөнгийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэсэн ангиллаас хасаж, дахин ангилсан бол уг санхүүгийн хөрөнгийг тэрхүү дахин ангиллын өдрөөрх түүний бодит үнэ цэнээр дахин ангилна. Ашиг, алдагдалд нэгэнт хүлээн зөвшөөрсөн аливаа олз, гарзыг буцаахгүй. Уг дахин ангиллын өдрөөрх санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь түүний шинэ өртөг буюу хэрэв хамааралтай бол хорогдуулсан өртөг болно.
57. Тухайн байгууллага нь санхүүгийн хөрөнгийг ойрын ирээдүйд эсвэл дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших санаа төлөвлөгөөтэй ба ийм чадвар, боломжтой тохиолдолд 53(в) параграфыг мөрддөг бөгөөд зээл, авлагын тодорхойлолтыг хангадаг санхүүгийн хөрөнгийг (хэрэв санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж ангилахыг шаардаагүй бол) ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэсэн ангиллаас хасаж, дахин ангилж болно.
58. Тухайн байгууллага нь санхүүгийн хөрөнгийг ойрын ирээдүйд эсвэл дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших санаа төлөвлөгөөтэй бөгөөд ийм чадвар, боломжтой тохиолдолд борлуулах боломжтой гэж ангилсан ба

зээл, авлагын тодорхойлолтыг хангадаг санхүүгийн хөрөнгийг (хэрэв үүнийг борлуулах боломжтой гэж ангилаагүй бол) борлуулах боломжтой гэсэн ангиллаас хасаж, зээл ба авлага ангилалд дахин ангилж болно.

59. Хэрэв байгууллага нь санхүүгийн хөрөнгийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэсэн ангиллаас 57-р параграфын дагуу хасаж, эсвэл борлуулах боломжтой гэсэн ангиллаас 58-р параграфын дагуу хасаж, дахин ангилсан бол уг байгууллага нь тухайн санхүүгийн хөрөнгийг тэрхүү дахин ангиллын өдрөөрх түүний бодит үнэ цэнээр дахин ангилна. 57-р параграфын дагуу дахин ангилсан санхүүгийн хөрөнгийн хувьд ашиг, алдагдалд нэгэнт хүлээн зөвшөөрсөн олз буюу гарзыг буцаахгүй. Уг дахин ангиллын өдрөөрх санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь түүний шинэ өртөг буюу хэрэв хамааралтай бол хорогдуулсан өртөг болно. Борлуулах боломжтой гэсэн ангиллаас 58-р параграфын дагуу хасаж, дахин ангилсан санхүүгийн хөрөнгийн хувьд 64(б) параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн тухайн хөрөнгийн аливаа өмнөх олз буюу гарзыг 63-р параграфт зааснаар тайлагнана.
60. **Санаа зорилго буюу чадвар боломжийн өөрчлөлтийн улмаас хөрөнгө оруулалтыг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмшиж буй гэж ангилах нь цаашид тохиромжгүй болсон тохиолдолд уг хөрөнгө оруулалтыг борлуулах боломжтой гэж дахин ангилж, бодит үнэ цэнээр дахин хэмжих бөгөөд түүний дансны үнэ ба бодит үнэ цэнийн хоорондох зөрүүг 64(б) параграфын дагуу тайлагнана.**
61. **Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмшиж буй мэдэгдэхүйц бус хэмжээнээс илүү дүн бүхий хөрөнгө оруулалтын борлуулалт буюу дахин ангилал нь 10-р параграфт заасан аль нэг нөхцлийг хангахгүй бол дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших аливаа үлдсэн хөрөнгө оруулалтыг борлуулах боломжтой гэж дахин ангилна. Ийм дахин ангиллын өдөр түүний дансны үнэ ба бодит үнэ цэнийн хоорондох зөрүүг 64(б) параграфын дагуу тайлагнана.**
62. Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн хувьд өмнө нь боломжгүй байсан боловч одоо найдвартай хэмжилт хийх боломжтой болсон бөгөөд хэрэв найдвартай хэмжих боломжтой бол тухайн хөрөнгө, өр төлбөрийг бодит үнэ цэнээр хэмжихийг шаарддаг (48(в) ба 49-р параграфыг үзнэ үү) бол тэрхүү хөрөнгө, өр төлбөрийг бодит үнэ цэнээр дахин хэмжиж, түүний дансны үнэ ба бодит үнэ цэнийн хоорондох зөрүүг 64-р параграфын дагуу тайлагнана.
63. **Санаа зорилго буюу чадвар боломжийн өөрчлөлтийн улмаас эсвэл бодит үнэ цэнийн найдвартай хэмжилтийг цаашид хийж чадахгүй цөөн ховор тохиолдолд (48(в) ба 49-р параграфыг үзнэ үү) эсвэл 10-р параграфт дурдсан, “өмнөх хоёр санхүүгийн жил” өнгөрсөн учраас санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг бодит үнэ цэнээр биш, харин өртөг буюу хорогдуулсан өртгөөр бүртгэх нь тохиромжтой болсон тохиолдолд тэрхүү өдрөөрх уг санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнэ нь түүний шинэ өртөг буюу**

хэрэв хамааралтай бол хорогдуулсан өртөг болно. 64(б) параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн тухайн хөрөнгийн аливаа өмнөх олз буюу гарзыг дараах байдлаар тайлагнана:

- (а) Тогтмол дуусгавар хугацаатай санхүүгийн хөрөнгийн хувьд олз, гарзыг тухайн дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын үлдэж буй хугацааны туршид үр ашигт хүүний арга ашиглан ашиг, алдагдалд хорогдуулан хуваарилна. Уг хорогдуулсан шинэ өртөг ба дуусгавар болох дүн хоорондох аливаа зөрүүг тухайн санхүүгийн хөрөнгийн үлдэх ашиглалтын хугацаанд урамшуулал ба хөнгөлөлтийн хорогдуулгатай адилаар мөн үр ашигт хүүний арга ашиглан хорогдуулна. Хэрэв санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ дараагийн тайлант үед буурсан бол цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн аливаа олз буюу гарзыг 76-р параграфын дагуу ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.
- (б) Тогтмол дуусгавар хугацаагүй санхүүгийн хөрөнгийн хувьд олз, гарз нь уг санхүүгийн хөрөнгийг борлуулах буюу бусад байдлаар данснаас хасах хүртэл цэвэр хөрөнгө/өмчид хэвээр үлдэх бөгөөд данснаас хассан үед ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Хэрэв санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ дараагийн тайлант үед буурсан бол цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн аливаа олз буюу гарзыг 76-р параграфын дагуу ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

#### Олз ба гарз

64. Хейжийн харилцааны нэг хэсэг болдоггүй санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүсэх олз, гарзыг (99-113-р параграфыг үзнэ үү) дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:
- (а) Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилдаг санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.
  - (б) Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгийн олз, гарз (үнэ цэнийн бууралтын гарзаас бусад тохиолдолд УСНББОУС 1-ийг үзнэ үү (76-79-р параграф)) болон гадаад валютын ханшийн олз, гарзыг (Хавсралт А-гийн МЗУ116-р параграфыг үзнэ үү) тухайн санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх хүртэл цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлангаар дамжуулан цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрөх бөгөөд уг санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх үед өмнө нь цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрч байсан, хуримтлагдсан олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Харин үр ашигт хүүний аргыг ашиглан тооцоолсон хүүг (10-р параграфыг үзнэ үү) ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө (УСНББОУС 9-ийг үзнэ



үү). Борлуулах боломжтой өмчийн хэрэглүүрийн ногдол ашиг буюу адилтгах хуваарилалтыг уг төлбөрийг хүлээн авах тухайн байгууллагын эрхийг тогтоосон үед ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө (УСНББОУС 9-ийг үзнэ үү).

65. **Хорогдуулсан өртгөөр бүртгэдэг санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн хувьд (48 ба 49-р параграфыг үзнэ үү) олз, гарзыг тухайн санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрсөн буюу үнэ цэнэ буурсан үед болон хорогдуулгыг тооцох явцад ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Харин хейжийн зүйл болох санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн хувьд (87-94-р параграф болон Хавсралт А-гийн МЗУ131-МЗУ141-р параграфыг үзнэ үү) түүний олз, гарзын тайлагналд 99-113-р параграфыг мөрдөнө.**
66. **Хэрэв байгууллага нь барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийг ашиглан санхүүгийн хөрөнгийг хүлээн зөвшөөрдөг бол (40-р параграф болон Хавсралт А-гийн МЗУ68, МЗУ71-р параграфыг үзнэ үү) арилжааны өдөр ба барагдуулалтын өдрийн хоорондох хугацаанд хүлээн авах тухайн хөрөнгийн бодит үнэ цэнийн аливаа өөрчлөлтийг (үнэ цэнийн бууралтын гарзаас бусад) өртгөөр эсвэл хорогдуулсан өртгөөр нь хэмждэг хөрөнгүүдийн хувьд хүлээн зөвшөөрөхгүй. Харин бодит үнэ цэнээр нь хэмждэг хөрөнгүүдийн хувьд бодит үнэ цэнийн өөрчлөлтийг 64-р параграфын дагуу ашиг, алдагдал эсвэл цэвэр хөрөнгө/өмчийн аль тохиромжтойд хүлээн зөвшөөрнө.**

#### **Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт ба үл цуглуулагдах байдал**

67. **Байгууллага нь санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн хөрөнгүүдийн бүлгийн үнэ цэнэ буурсан гэсэн ямар нэг бодит нотолгоо байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст үнэлж үзнэ. Хэрэв ийм ямар нэг нотолгоо байгаа бол байгууллага нь аливаа үнэ цэнийн бууралтын гарзын дүнг тодорхойлохын тулд 72-р параграф (хорогдуулсан өртгөөр бүртгэсэн санхүүгийн хөрөнгийн хувьд), 75-р параграф (өртгөөр бүртгэсэн санхүүгийн хөрөнгийн хувьд) эсвэл 7-р параграфыг (борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгийн хувьд) мөрдөнө.**
68. Санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа гарч тохиолдсон бөгөөд найдвартайгаар тооцоолж чадах тухайн санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн хөрөнгүүдийн бүлгийн ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээнд нөлөө үзүүлэх нэг буюу хэд хэдэн үйл явдлуудын (“гарзын үйл явдал”) үр дүнд үнэ цэнийн бууралт гарсан гэсэн бодит нотолгоо байгаа бол, зөвхөн тийм тохиолдолд санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн хөрөнгүүдийн бүлгийн үнэ цэнэ буурсан бөгөөд үнэ цэнийн бууралтын гарз үүссэн гэж үзнэ. Үнэ цэнийн бууралтанд хүргэсэн ганц, тусдаа үйл явдлыг тодорхойлох боломжгүй байж болох юм. Харин хэд хэдэн үйл явдлуудын нэгдсэн үр нөлөө нь үнэ цэнийн бууралтын шалтгаан байж болно. Ирээдүйн үйл явдлуудын үр дүнд хүлээгдэж буй гарзыг хэр магадлалтай гэдгээс үл хамааран хүлээн зөвшөөрөхгүй. Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн

хөрөнгүүдийн бүлгийн үнэ цэнэ буурсан талаархи бодит нотолгоонд тухайн хөрөнгийн эзэмшигчийн анхааралд өртсөн бөгөөд дараах гарзын үйл явдлуудын талаархи ажиглаж болох мэдээ хамаарна:

- (a) Гаргагч эсвэл зээлдэгчийн санхүүгийн мэдэгдэхүйц хүндрэлтэй байдал;
- (б) Гэрээний зөрчил, жишээлбэл; хүү буюу үндсэн дүнг төлөхгүй байх эсвэл хугацаа хэтрэх;
- (в) Зээлдүүлэгч нь уг зээлдэгчийн санхүүгийн хүндрэлтэй байдалтай холбоотой эдийн засгийн буюу хуулийн учир шалтгааны улмаас өөр бусад нөхцөлд зөвшөөрөхөөргүй хөнгөлөлтийг тухайн зээлдэгчид үзүүлэх;
- (г) Зээлдэгч нь дампуурах эсвэл санхүүгийн бусад дахин зохион байгуулалт хийх нилээд магадлалтай байх;
- (д) Санхүүгийн хүндрэлтэй байдлын улмаас уг санхүүгийн хөрөнгийн хувьд идэвхитэй зах зээлгүй болох;
- (e) Санхүүгийн хөрөнгүүдийн бүлгээс үүсэх, ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээний бууралтыг тухайн бүлэг дэх бие даасан санхүүгийн хөрөнгүүдээр хараахан тодорхойлж чадахгүй боловч тэдгээр хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш тэрхүү ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээнд хэмжиж болохуйц бууралт гарсан гэдгийг илэрхийлэх ажиглаж болох мэдээ, үүнд:
  - (i) Тухайн бүлэг дэх зээлдэгчдийн төлөв байдалд орсон сөрөг өөрчлөлтүүд (жишээлбэл; хойшлогдсон төлбөрийн тоо нэмэгдэлт); эсвэл
  - (ii) Тухайн бүлэг дэх хөрөнгүүдийн үл биелүүлэлттэй уялдаа холбоотой үндэсний буюу орон нутгийн эдийн засгийн нөхцөл байдал (жишээлбэл; зээлдэгчийн газар зүйн бүс нутаг дахь ажилгүйдлийн түвшний өсөлт, газрын тос үйлдвэрлэгчийн зээлийн хөрөнгийн хувьд газрын тосны үнийн бууралт эсвэл тухайн бүлэг дэх зээлдэгчид нөлөө үзүүлэх салбарын нөхцөл байдлын сөрөг өөрчлөлт).

69. Байгууллагын санхүүгийн хэрэглүүрийг цаашид олон нийтэд арилжихаа больсоны улмаас идэвхитэй зах зээлгүй болох нь үнэ цэнийн бууралтын нотолгоо биш юм. Байгууллагын зээлийн үнэлэмжийн бууралт нь бусад боломжит мэдээллийн хамт авч үзэх үед үнэ цэнийн бууралтын нотолгоо байж болох боловч энэ нь дангаараа, үнэ цэнийн бууралтын нотолгоо болохгүй. Санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ түүний өртөг буюу хорогдуулсан өртгөөс бага болох бууралт нь үнэ цэнийн бууралтын нотолгоо байх албагүй юм (жишээлбэл; эрсдэлгүй хүүний түвшний өсөлтийн үр дүнд өрийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ буурах).

70. 68-р параграфт дурдсан, үйл явдлуудын төрлүүдээс гадна өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын бодит

нотолгоонд уг гаргагчийн үйл ажиллагаагаа явуулдаг технологийн, зах зээлийн, эдийн засгийн буюу хуулийн орчинд гарсан сөрөг үр нөлөө бүхий мэдэгдэхүйц өөрчлөлтүүдийн талаархи мэдээлэл хамаарах бөгөөд уг өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтын өртөг нөхөгдөхгүй байж болно гэдгийг илэрхийлдэг. Өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ түүний өртгөөс бага болох мэдэгдэхүйц буюу урт хугацааны бууралт нь мөн үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо юм.

71. Зарим тохиолдолд санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарзын дүнг тооцоолоход шаардлагатай ажиглаж болох мэдээ нь хязгаарлагдмал байх эсвэл одоогийн нөхцөл байдалд бүрэн хамааралтай байхаа цаашид больсон байж болох юм. Жишээлбэл; зээлдэгч нь санхүүгийн хүндрэлд орсон ба ижил төсөөтэй зээлдэгчдийн талаархи бэлэн боломжтой түүхэн мэдээ хомс бол ийм тохиолдол үүсэж болно. Ийм тохиолдолд байгууллага нь аливаа үнэ цэнийн бууралтын гарзын дүнг тооцоолохдоо өөрийн туршлагад үндэслэсэн шүүн тунгаалтыг ашигладаг. Үүнтэй адилаар, одоогийн нөхцөл байдлыг тусгахын тулд байгууллага нь санхүүгийн хөрөнгүүдийн бүлгийн талаархи ажиглаж болох мэдээг тохируулахдаа өөрийн туршлагад үндэслэсэн шүүн тунгаалтыг ашигладаг (МЗУ122-р параграфыг үзнэ үү). Ул үндэслэлтэй тооцоолол ашиглах нь санхүүгийн тайлан бэлтгэлтийн чухал хэсэг бөгөөд түүний найдвартай байдлыг алдагдуулдаггүй.<sup>3</sup>

*Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн санхүүгийн хөрөнгө*

72. **Хорогдуулсан өртгөөр бүртгэдэг зээл ба авлага эсвэл дуусгавар болох хугацаа хүртэл эзэмшиж буй хөрөнгө оруулалтанд үнэ цэнийн бууралтын гарз учирсан гэсэн бодит нотолгоо байгаа бол уг санхүүгийн хөрөнгийн анхны үр ашигт хүүний түвшнээр (өөрөөр хэлбэл, анх хүлээн зөвшөөрөх үед тооцоолсон үр ашигт хүүний түвшин) дискаунтчилсан ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээний (хараахан гарч тохиолдоогүй байгаа ирээдүйн зээлийн алдагдлыг оруулахгүй) өнөөгийн үнэ цэнэ ба тэрхүү хөрөнгийн дансны үнэ хоорондох зөрүүгээр гарзын дүнг хэмжинэ. Тухайн хөрөнгийн дансны үнийг шууд эсвэл хасагдуулгын данс ашигласнаар бууруулна. Гарзын дүнг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.**
73. Үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо нь санхүүгийн хөрөнгийн хувьд бие даасан байдлаараа мэдэгдэхүйц дүнтэй, эсвэл бие даасан байдлаараа мэдэгдэхүйц биш боловч хамтдаа мэдэгдэхүйц дүнтэй байгаа эсэхийг байгууллага нь эхлээд үнэлнэ (68-р параграфыг үзнэ үү). Хэрэв байгууллага нь бие даасан байдлаар үнэлсэн санхүүгийн хөрөнгийн хувьд мэдэгдэхүйц үгүй эсэхээс үл хамааран үнэ цэнийн бууралтын бодит

<sup>3</sup> Найдвартай мэдээлэл нь материаллаг алдаа ба туйлшралаас ангид байх бөгөөд өөрийн илэрхийлэхээр зориулагдсан буюу илэрхийлнэ гэж ул үндэслэлтэйгээр хүлээж болох зүйлсийг үнэн зөв илэрхийлэхдээ хэрэглэгчдээс хамаардаг байж болох юм. Найдвартай байдлын тайлбарын талаархи шилжилтийн арга хандлагыг УСНББОУС 1-ийн ДҮ16-р параграфт авч хэлэлцсэн.

нотолгоо байхгүй гэж тодорхойлсон бол тухайн хөрөнгийг ижил төсөөтэй зээлийн эрсдлийн шинж чанар бүхий санхүүгийн хөрөнгүүдийн бүлэгт тусган оруулах бөгөөд үнэ цэнийн бууралтын хувьд тэдгээрийг хамтад нь үнэлнэ. Үнэ цэнийн бууралтын хувьд бие даасан байдлаар үнэлсэн бөгөөд үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрсөн буюу хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа хөрөнгүүдийг тэрхүү үнэ цэнийн бууралтын хамтын үнэлгээнд тусган оруулахгүй.

74. Хэрэв дараагийн тайлант үед үнэ цэнийн бууралтын гарзын дүн буурсан бөгөөд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараа гарч тохиолдсон үйл явдалд (зээлдэгчийн зээлийн үнэлэмж сайжрах гэх мэт) тэрхүү бууралтыг бодитойгоор хамааруулж болохоор байвал өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг шууд эсвэл хасагдуулгын дансыг тохируулах замаар буцаана. Ийм буцаалт нь хэрэв үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрдөггүй байсан бол тэрхүү үнэ цэнийн бууралтыг буцаасан өдрөөрх тухайн санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртгөөс түүний дансны үнийг илүү болгохооргүй байна. Буцаалтын дүнг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

*Өртгөөр бүртгээсэн санхүүгийн хөрөнгө*

75. Бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжиж чадахгүй, иймээс бодит үнэ цэнээр бүртгэдэггүй, жишиг зах зээлийн үнэгүй өмчийн хэрэглүүрийн хувьд эсвэл ийм жишиг зах зээлийн үнэгүй өмчийн хэрэглүүртэй холбоотой бөгөөд түүнийг өгснөөр барагдуулах ёстой үүсмэл хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын гарз үүссэн гэсэн бодит нотолгоо байгаа бол ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгийн одоогийн зах зээлийн өгөөжийн түвшнээр дискаунтчилсан, ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ ба тухайн санхүүгийн хөрөнгийн дансны үнэ хоорондох зөрүүгээр тэрхүү үнэ цэнийн бууралтын гарзын дүнг хэмжинэ (48(в) параграф болон Хавсралт А-гийн МЗУ113, МЗУ114-р параграфыг үзнэ үү). Ийм үнэ цэнийн бууралтын гарзыг буцаахгүй.

*Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө*

76. Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн бууралтыг цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрдөг бөгөөд тухайн хөрөнгийн үнэ цэнэ буурсан гэсэн бодит нотолгоо байгаа (68-р параграфыг үзнэ үү) тохиолдолд хэдийгээр санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөөгүй ч гэсэн цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн, хуримтлагдсан гарзыг цэвэр хөрөнгө/өмчөөс хасаж, ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.
77. 76-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчөөс хасаж, ашиг алдагдалд хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан гарзын дүн нь уг санхүүгийн хөрөнгийн хувьд ашиг, алдагдалд өмнө нь хүлээн зөвшөөрсөн аливаа үнэ цэнийн бууралтын гарзыг хассан одоогийн бодит үнэ цэнэ ба

тухайн олж эзэмшилтийн өртгийн (үндсэн дүнгийн аливаа буцаан төлөлт ба хорогдуулгыг хассан цэвэр дүн) хоорондох зөрүү юм.

78. Борлуулах боломжтой гэж ангилсан өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтын хувьд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдлаас буцаахгүй.
79. Борлуулах боломжтой гэж ангилсан өрийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ нь дараагийн тайлант үед өссөн бөгөөд үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөний дараа гарч тохиолдсон үйл явдалтай уг өсөлтийг бодитойгоор хамааруулж чадах тохиолдолд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн буцаалтын дүнгийн хамтаар тэрхүү үнэ цэнийн бууралтын гарзыг буцаана.

## Хейж

80. 95-98-р параграф болон Хавсралт А-гийн МЗУ142-МЗУ144-р параграфт заасанчлан, хейжийн хэрэглүүр ба хейжийн зүйлийн хооронд сонгосон хейжийн харилцаа оршин байгаа бол уг хейжийн хэрэглүүр болон хейжийн зүйлийн олз, гарзын тайлагналд 99-113-р параграфыг мөрдөнө.

## Хейжийн хэрэглүүр

### *Шалгуур хангах хейжийн хэрэглүүр*

81. Хэрэв 98-р параграфт заасан нөхцлүүд хангагдаж байвал гаргасан зарим опционоос бусад үүсмэл хэрэглүүрийг хейжийн хэрэглүүрээр сонгож болох нөхцөл байдлуудыг энэхүү Стандартаар хязгаарладаггүй (Хавсралт А-гийн МЗУ127-р параграфыг үзнэ үү). Гэхдээ үүсмэл бус санхүүгийн хөрөнгө буюу үүсмэл бус санхүүгийн өр төлбөрийг зөвхөн гадаад валютын эрсдлийн хейжийн хувьд хейжийн хэрэглүүр гэж сонгож болно.
82. Тухайн тайлагнагч байгууллагын хувьд гадны (өөрөөр хэлбэл, уг тайлагнаж буй эдийн засгийн нэгдмэл байгууллага эсвэл бие даасан байгууллагын хувьд гадны) этгээд болох тийм оролцогч тал бүхий зөвхөн тэдгээр хэрэглүүрийг хейжийн нягтлан бодох бүртгэлийн зорилгоор хейжийн хэрэглүүр гэж сонгож болно. Нэг эдийн засгийн нэгдмэл байгууллагад хамаарах бие даасан байгууллагууд эсвэл нэг байгууллагын хүрээн дэх хэлтсүүд нь тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагад хамаарах бусад байгууллагуудтай эсвэл уг байгууллагын доторх бусад хэлтсүүдтэй хейжийн ажил гүйлгээ хийж болох боловч нэгтгэл хийх үед уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын доторх ийм аливаа ажил гүйлгээг устгаж, цэвэрлэнэ. Тийм учраас ийм хейжийн ажил гүйлгээ нь тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангахгүй. Гэвч уг эдийн засгийн нэгдмэл байгууллагад хамаарах байгууллагууд нь тухайн тайлагнаж буй байгууллагын хувьд гаднын тал байх тохиолдолд ийм хейжийн ажил гүйлгээ нь тэдгээр бие даасан байгууллагуудын тусдаа санхүүгийн

тайлангийн хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангаж болно.

*Хейжийн хэрэглүүрийн сонголт*

83. Ерөнхийдөө хейжийн хэрэглүүрийг бүхэлд нь нэг бодит үнэ цэнээр хэмждэг бөгөөд бодит үнэ цэнэ өөрчлөгдөхөд хүргэх хүчин зүйлс нь хоорондоо харилцан уялдаатай байдаг. Иймээс байгууллага нь хейжийн хэрэглүүрт бүхэлд нь хамаарах хейжийн харилцааг сонгодог. Зөвхөн дараах гажих тохиолдлыг зөвшөөрдөг. Үүнд:

(а) опционы гэрээний дотоод үнэ цэнэ ба цаг хугацааны үнэ цэнийг салган зааглаж, уг опционы зөвхөн дотоод үнэ цэнийн өөрчлөлтийг хейжийн хэрэглүүр гэж сонгох бөгөөд түүний цаг хугацааны үнэ цэнийн өөрчлөлтийг харгалзан үзэхгүй байх; ба

(б) форвард гэрээний хүүний бүрэлдэхүүн хэсэг ба спот үнийг салган зааглах.

Опционы дотоод үнэ цэнэ ба форвард гэрээний урамшууллыг ерөнхийдөө тусад нь хэмждэг тул эдгээр гажих тохиолдлыг зөвшөөрдөг. Опционы гэрээний дотоод үнэ цэнэ ба цаг хугацааны үнэ цэнийн аль алиныг үнэлдэг хейжийн идэвхитэй стратеги нь хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангана.

84. Нийт хейжийн хэрэглүүрийн нэрлэсэн дүнгийн 50 хувь гэх мэт тодорхой хэсгийг тухайн хейжийн харилцаанд хейжийн хэрэглүүр гэж сонгож болно. Гэхдээ хейжийн хэрэглүүр эргэлтэнд байх үед хейжийн харилцааг зөвхөн түүний цаг хугацаанд хамаарах хэсгийн хувьд сонгож болохгүй.

85. Дараах тохиолдолд нэг хейжийн хэрэглүүрийг нэгээс олон төрлийн эрсдлийн хейж гэж сонгож болно: (а) хейж хийсэн эрсдлүүдийг оновчтой тодорхойлж болох; (б) тухайн хейжийн үр дүнтэй байдлыг батлан харуулж чадах; (в) эрсдлийн өөр өөр төлөв байдлын хувьд хейжийн хэрэглүүрийг тусгайлан сонгосон гэдгийг батлан харуулах боломжтой байх.

86. Хоёр буюу хэд хэдэн үүсмэл хэрэглүүрийг эсвэл тэдгээрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг (валютын эрсдлийн хейжийн хувьд хоёр буюу хэд хэдэн үүсмэл бус хэрэглүүр эсвэл тэдгээрийн бүрэлдэхүүн хэсгүүд, үүсмэл ба үүсмэл бус хэрэглүүрүүдийн эсвэл тэдгээрийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нэгдлийг) нэгтгэн авч үзэх ба хамтад нь хейжийн хэрэглүүр гэж сонгож болно. Үүнд: зарим үүсмэл хэрэглүүрээс үүсэх эрсдэл нь өөр үүсмэл хэрэглүүрээс үүсэх эрсдлийг нөхдөг тохиолдол хамаарна. Гэхдээ хүүний түвшний баталгаа эсвэл гаргасан опцион ба худалдан авсан опционыг нэгтгэсэн бусад үүсмэл хэрэглүүр нь хэрэв эцсийн үр дүнгээрээ, гаргасан цэвэр опцион болохоор (үүний хувьд цэвэр урамшуулал авахаар) байвал хейжийн хэрэглүүрийн шалгуурыг хангахгүй юм. Үүнтэй адилаар, хоёр буюу хэд хэдэн хэрэглүүрийн (эсвэл тэдгээрийн бүрэлдэхүүн хэсгийн) аль нь ч гаргасан опцион эсвэл гаргасан цэвэр опцион биш байх зөвхөн тийм тохиолдолд тэдгээрийг хейжийн хэрэглүүр гэж сонгож болно.

## Хейжийн зүйлс

### Шалгуур хангах хейжийн зүйлс

87. Хейжийн зүйл нь хүлээн зөвшөөрсөн хөрөнгө, өр төлбөр, хүлээн зөвшөөрөөгүй арилжааны баталгаа, хэрэгжих өндөр магадлалтай урьдчилан таамагласан ажил гүйлгээ, гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалт байж болно. Хейжийн зүйл нь (а) нэг хөрөнгө, өр төлбөр, арилжааны баталгаа, хэрэгжих өндөр магадлалтай урьдчилан таамагласан ажил гүйлгээ, гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалт, (б) ижил төсөөтэй эрсдлийн шинж чанар бүхий бүлэг хөрөнгө, өр төлбөр, арилжааны баталгаа, хэрэгжих өндөр магадлалтай урьдчилан таамагласан ажил гүйлгээ, гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалт, (в) зөвхөн хүүний түвшний эрсдлийн багц хейжийн хувьд, уг хейж хийгдэж буй эрсдлийг хуваалцаж байгаа тухайн санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн багцын тэрхүү хэсэг байж болно.
88. Хөрөнгө оруулалтыг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших гэж ангилах нь хүүний түвшний өөрчлөлтийн улмаас уг хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ буюу мөнгөн гүйлгээнд гарах өөрчлөлтөөс үл хамааран тухайн хөрөнгө оруулалтыг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших санаа зорилготой байхыг шаарддаг тул зээл ба авлагаас ялгаатай нь, ийм дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт нь хүүний түвшний эрсдэл болон урьдчилан төлөх эрсдлийн хувьд хейжийн зүйл болж чадахгүй. Харин дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт нь гадаад валютын ханшийн өөрчлөлтийн эрсдэл болон зээлийн эрсдлийн хувьд хейжийн зүйл байж болно.
89. Тухайн тайлагнагч байгууллагын хувьд гадны этгээд болох тийм оролцогч тал бүхий зөвхөн тэдгээр хөрөнгө, өр төлбөр, арилжааны баталгаа, хэрэгжих өндөр магадлалтай урьдчилан таамагласан ажил гүйлгээг хейжийн нягтлан бодох бүртгэлийн зорилгоор хейжийн зүйл гэж сонгож болно. Эндээс дараах дүгнэлт хийнэ. Үүнд: нэг эдийн засгийн нэгдмэл байгууллагад хамаарах байгууллагуудын хооронд хийгдсэн бөгөөд уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд биш, харин зөвхөн тэдгээр байгууллагуудын бие даасан буюу тусдаа санхүүгийн тайланд тусгагдах ажил гүйлгээний хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэнэ. Харин үүнээс гажих тохиолдол нь хөрөнгө оруулалтын байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлан бөгөөд УСНББОУС 35-д тодорхойлсноор, хөрөнгө оруулалтын байгууллага ба ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн түүний хяналтанд буй байгууллагуудын хооронд хийгдсэн ажил гүйлгээг уг нэгтгэсэн санхүүгийн тайланд устгаж, цэвэрлэдэггүй тул түүнд хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэнэ. Эдийн засгийн нэгдмэл байгууллагын доторх мөнгөн зүйлсийн (жишээлбэл; хяналтанд буй хоёр байгууллагын хооронд үүссэн өглөг/авлага) гадаад валютын эрсдэл нь гадаад валютын ханшийн олз, гарз үүсэхэд хүргэдэг бөгөөд нэгтгэл хийх үед түүнийг УСНББОУС 4, *Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө*-ний дагуу бүрэн устгаж, цэвэрлэдэггүй бол энэ нь бас нэг гажих нөхцөл болох бөгөөд уг

нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд хейжийн зүйл болох шалгуурыг хангаж болох юм. Эдийн засгийн нэгдмэл байгууллагын доторх мөнгөн зүйл нь өөр өөр бүртгэлийн валют ашигладаг, нэг эдийн засгийн нэгдмэл байгууллагын доторх хоёр байгууллагын хоорондох ажил гүйлгээгээр үүссэн тохиолдолд нэгтгэл хийхдээ тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын доторх мөнгөн зүйлсийн гадаад валютын ханшийн олз, гарзыг УСНББОУС 4-ийн дагуу бүрэн устгаж, цэвэрлэдэггүй. Мөн эдийн засгийн нэгдмэл байгууллагын доторх, хэрэгжих өндөр магадлалтай урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь тухайн ажил гүйлгээг хийж буй байгууллагын бүртгэлийн валютаас өөр валютаар илэрхийлэгдсэн бөгөөд түүний гадаад валютын эрсдэл нь нэгтгэсэн ашиг, алдагдалд нөлөөлөхөөр бол уг ажил гүйлгээний гадаад валютын эрсдэл нь тэрхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд хейжийн зүйл болох шалгуурыг хангаж болох юм.

*Санхүүгийн зүйлсийг хейжийн зүйлс гэж сонгох*

90. Хейжийн зүйл нь санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр байх тохиолдолд үр дүнтэй байдлыг нь хэмжиж чадах түүний мөнгөн гүйлгээний эсвэл бодит үнэ цэнийн зөвхөн тэрхүү хэсэгтэй (тухайлбал; гэрээний нэг болон хэд хэдэн сонгосон мөнгөн гүйлгээ буюу тэдгээрийн бүрэлдэхүүн хэсгүүдтэй, эсвэл бодит үнэ цэнийн тодорхой хувийн жинтэй) холбоотой эрсдлийн хувьд уг санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр нь хейжийн зүйл байж болно. Жишээлбэл; хүүтэй хөрөнгө буюу хүүтэй өр төлбөрийн хүүний түвшний эрсдлээс зөвхөн тодорхойлж болох ба тусад нь хэмжиж болох тэрхүү хэсгийг (хейж хийсэн санхүүгийн хэрэглүүрийн нийт хүүний түвшний эрсдлээс тэрхүү эрсдэлгүй хүүний түвшин эсвэл бенчмарк хүүний түвшин бүхий бүрэлдэхүүн хэсэг гэх мэт) хейж хийсэн эрсдэл гэж сонгож болно.
91. Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн багцын хүүний түвшний эрсдэлд хамаарах бодит үнэ цэнийн хейжийн (зөвхөн ийм хейжийн) хувьд, тухайн хейж хийгдэх хэсгийг уг бие даасан хөрөнгө (буюу өр төлбөр)-өөр биш, харин валютын дүнгээр (жишээлбэл; долларын, евроны, фунт стирлингийн эсвэл рандын дүнгээр) сонгож болно. Эрсдлийн удирдлагын зорилгоор, тухайн багц нь хөрөнгө ба өр төлбөрийг хоёуланг нь агуулсан байж болох боловч уг сонгосон дүн нь хөрөнгө эсвэл өр төлбөрийн аль нэгний дүн байна. Хөрөнгө ба өр төлбөрийн аль алиныг агуулсан цэвэр дүн сонгохыг зөвшөөрөхгүй. Байгууллага нь зөвхөн тухайн сонгосон дүнтэй холбоотой хүүний түвшний эрсдлийн хэсэгт хейж хийж болно. Жишээлбэл; төлбөрийг нь урьдчилан төлөх хөрөнгийг агуулсан багцын хейжийн хувьд, байгууллага нь хүүний түвшинг дахин хянан үзэх гэрээний огноонд биш, харин хүлээгдэж буй огноонд үндэслэн уг хейж хийсэн хүүний түвшний өөрчлөлтөнд хамаарах бодит үнэ цэнийн өөрчлөлтөнд хейж хийж болно. Хейж хийх хэсэг нь хүүний түвшинг дахин хянан үзэх хүлээгдэж буй огноонд үндэслэдэг тохиолдолд тухайн хейж хийсэн хүүний түвшний өөрчлөлтийн тэрхүү дахин хянан үзэх хүлээгдэж буй өдрөөрх үр нөлөөг уг хейжийн зүйлийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо харгалзан оруулна. Иймээс урьдчилан төлөх зүйлсийг агуулсан багцыг ийм урьдчилсан төлбөргүй



үүсмэл хэрэглүүрээр хейж хийсэн тохиолдолд уг хейж хийсэн багц дахь зүйлсийг урьдчилан төлөхөөр хүлээгдэж буй огноог өөрчилсөн эсвэл урьдчилсан төлбөрийн бодит огноо нь тэрхүү хүлээгдэж буй огнооноос өөр байвал үр дүнгүй байдал үүснэ.

*Санхүүгийн бус зүйлсийг хейжийн зүйлс гэж сонгох*

92. **Хейжийн зүйл нь санхүүгийн бус хөрөнгө эсвэл санхүүгийн бус өр төлбөр байх тохиолдолд гадаад валютын эрсдлээс бусад, тодорхой эрсдлүүдтэй холбоотой түүний мөнгөн гүйлгээний эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлтийн холбогдох хэсгийг салган тусгаарлах ба хэмжих хүндрэлтэй байдлын улмаас уг санхүүгийн бус хөрөнгө буюу санхүүгийн бус өр төлбөрийг (а) гадаад валютын эрсдлийн хувьд, эсвэл (б) бүхэлд нь бүх эрсдлийн хувьд хейжийн зүйл гэж сонгоно.**

*Зүйлсийн бүлгүүдийг хейжийн зүйлс гэж сонгох*

93. Тухайн бүлэг дэх бие даасан хөрөнгө буюу өр төлбөр нь хейж хийгдэж буй гэж сонгосон уг эрсдлийг хуваалцдаг зөвхөн тийм тохиолдолд ижил төсөөтэй хөрөнгө буюу ижил төсөөтэй өр төлбөрийг бүлэг болгон нэгтгэн нийлүүлж, хейж хийнэ. Түүнчлэн, бүлэг дэх бие даасан зүйл тус бүрийн хувьд хейж хийсэн эрсдэлтэй холбоотой бодит үнэ цэнийн өөрчлөлт нь тухайн бүлгийн хувьд хейж хийсэн эрсдэлтэй холбоотой бодит үнэ цэнийн нийт өөрчлөлттэй ойролцоогоор шууд хамааралтай байна гэж үздэг.
94. Байгууллага нь хейжийн хэрэглүүр (буюу ижил төсөөтэй хейжийн хэрэглүүрүүдийн бүлэг) ба хейжийн зүйлийн (буюу ижил төсөөтэй хейжийн зүйлсийн бүлгийн) бодит үнэ цэнийн эсвэл мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг харьцуулснаар хейжийн үр дүнтэй байдлыг үнэлдэг тул хейж хийсэн тухайн нэг зүйлтэй биш, харин ерөнхий цэвэр дүнтэй (жишээлбэл; дуусгавар болох ижил төсөөтэй хугацаатай, тогтмол хүүтэй бүх хөрөнгө ба тогтмол хүүтэй бүх өр төлбөрийн цэвэр дүнтэй) уг хейжийн хэрэглүүрийг харьцуулах нь хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангахгүй юм.

### **Хейжийн нягтлан бодох бүртгэл**

95. Хейжийн нягтлан бодох бүртгэл нь хейжийн хэрэглүүр ба хейжийн зүйлийн бодит үнэ цэнүүдийн өөрчлөлтөөр ашиг, алдагдалд үзүүлэх цэвэр үр нөлөөг хүлээн зөвшөөрдөг.
96. **Хейжийн харилцаа нь дараах гурван төрөлтэй байдаг:**
- (а) **Бодит үнэ цэнийн хейж: хүлээн зөвшөөрсөн хөрөнгө буюу өр төлбөрийн эсвэл хүлээн зөвшөөрөөгүй арилжааны баталгааны, эсвэл ийм хөрөнгө, өр төлбөр, арилжааны баталгааны тогтоосон бүрэлдэхүүн хэсгийн бодит үнэ цэнэд гарах бөгөөд тодорхой эрсдэлд хамааруулж болох, түүнчлэн ашиг, алдагдалд нөлөө үзүүлэх өөрчлөлтүүдийн хувьд хийгдэх хейж.**

- (б) Мөнгөн гүйлгээний хейж: дараах шинж бүхий мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлтийн хувьд хийгдэх хейж: (i) хүлээн зөвшөөрсөн хөрөнгө буюу өр төлбөртэй (хувьсах хүүтэй өрийн ирээдүйн бүх буюу зарим хүүний төлбөр гэх мэт) эсвэл хэрэгжих өндөр магадлалтай урьдчилан таамагласан ажил гүйлгээтэй холбоотой тодорхой эрсдэлд хамааруулж болох, ба (ii) ашиг, алдагдалд нөлөө үзүүлэх.
- (в) Гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хейж, үүнийг УСНББОУС 4-д тодорхойлсон.
97. Арилжааны баталгааны гадаад валютын эрсдлийн хейжийг бодит үнэ цэнийн хейж эсвэл мөнгөн гүйлгээний хейж гэж тайлагнаж болно.
98. Дараах бүх нөхцлүүд хангагдах зөвхөн тийм тохиолдолд хейжийн харилцаа нь 99-113-р параграфын дагуу хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангана:
- (а) Хейжийн эхэнд, уг хейжийн харилцаа, түүнчлэн хейжийг хийх тухайн байгууллагын эрсдлийн удирдлагын зорилго ба стратегийн талаархи албан ёсны сонголт болон баримтжуулалт хийгдсэн байх. Ийм баримтжуулалт нь хейжийн хэрэглүүр, хейжийн зүйл буюу ажил гүйлгээ, хейж хийгдэж буй эрсдлийн шинж төрөл, хейж хийсэн эрсдэлд хамаарах уг хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн буюу мөнгөн гүйлгээний өөрчлөлтийн эрсдлийг нөхөх тухайн хейжийн хэрэглүүрийн үр дүнтэй байдлыг тэрхүү байгууллага хэрхэн үнэлэх талаархи тодорхойлолтыг агуулсан байдаг.
- (б) Хейж нь уг хейж хийгдэж буй эрсдэлд хамаарах бодит үнэ цэнийн эсвэл мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг нөхөхөд өндөр үр дүнтэй (Хавсралт А-гийн МЗУ145-МЗУ156-р параграфыг үзнэ үү) бөгөөд тухайн хейжийн харилцааны хувьд анх баримтжуулсан эрсдлийн удирдлагын стратегитай нийцнэ гэж хүлээгдэж байх.
- (в) Мөнгөн гүйгээний хейжийн хувьд тухайн хейжийн зүйл болох урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь хэрэгжих өндөр магадлалтай байх ёстой бөгөөд ашиг, алдагдалд эцэстээ нөлөө үзүүлэх мөнгөн гүйлгээний хэлбэлзэл өөрчлөлтийн эрсдлийг илэрхийлдэг байх.
- (г) Хейжийн үр дүнтэй байдлыг найдвартай хэмжиж чадахаар байх. Өөрөөр хэлбэл, тухайн хейж хийсэн эрсдэлд хамаарах хейжийн зүйлийн бодит үнэ цэнэ буюу мөнгөн гүйлгээ болон хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадахаар байх (бодит үнэ цэнийг тодорхойлох талаархи заавар удирдамжийг 48, 49-р параграф болон Хавсралт А-гийн МЗУ113, МЗУ114-р параграфуудыг үзнэ үү).
- (д) Хейжийг тасралтгүй сууриар үнэлэх бөгөөд уг хейжийг сонгосон тухайн санхүүгийн тайлагналын үеийн туршид түүнийг өндөр үр дүнтэй байна гэдгийг бодитойгоор тодорхойлсон байх.

*Бодит үнэ цэнийн хейж*

99. **Хэрэв бодит үнэ цэнийн хейж нь тухайн тайлант үеийн туршид 98-р параграфт заасан нөхцлүүдийг хангаж байвал түүнийг дараах байдлаар тайлагнана:**
- (а) **Хейжийн хэрэглүүрийг (үүсмэл хейжийн хэрэглүүрийн хувьд) бодит үнэ цэнээр дахин хэмжсэнээр үүссэн эсвэл УСНББОУС 4-ийн дагуу хэмжсэн (үүсмэл бус хейжийн хэрэглүүрийн хувьд) түүний дансны үнэ дэх гадаад валютын бүрэлдэхүүн хэсгээс үүссэн олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө; ба**
  - (б) **Хейж хийсэн эрсдэлд хамаарах тухайн хейжийн зүйлийн олз, гарзаар энэхүү хейжийн зүйлийн дансны үнийг тохируулах ба ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Хейжийн зүйлийг өртгөөс өөрөөр хэмжсэн бол үүнийг мөрдөнө. Тухайн хейжийн зүйл нь борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө байх тохиолдолд уг хейж хийсэн эрсдэлд хамаарах олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.**
100. Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн багцын хүүний түвшний эрсдэлтэй хэсэгт хамаарах бодит үнэ цэнийн хейжийн (зөвхөн ийм хейжийн) хувьд уг хейжийн зүйлтэй холбоотой олз, гарзыг дараах хоёр хувилбарын аль нэгээр толилуулах замаар 99(б) параграф дахь шаардлагыг хангаж болох юм:
- (а) Тухайн хейжийн зүйл нь хөрөнгө байх тохиолдолд хүүний түвшинг дахин хянах тайлант үеүдэд хөрөнгийн доторх тусдаа нэг мөрийн зүйлд; эсвэл
  - (б) Тухайн хейжийн зүйл нь өр төлбөр байх тохиолдолд хүүний түвшинг дахин хянах тайлант үеүдэд өр төлбөрийн доторх тусдаа нэг мөрийн зүйлд.
- Дээрх (а), (б)-д дурдсан тусдаа мөрийн зүйлсийг санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн дараа толилуулна. Тэдгээрийн хамаарах хөрөнгө буюу өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрсөн үед эдгээр мөрийн зүйлсэд тусгасан дүнгүүдийг санхүүгийн байдлын тайлангаас хасна.
101. Хэрэв хейжийн зүйлд хамаарах зөвхөн зарим тодорхой эрсдэлд хейж хийдэг уг хейж хийсэн эрсдэлтэй холбоогүй хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн хүлээн зөвшөөрсөн өөрчлөлтийг 64-р параграфт заасны дагуу хүлээн зөвшөөрнө.
102. **Дараах тохиолдолд байгууллага нь 99-р параграфт заасан хейжийн нягтлан бодох бүртгэлийг цаашид үргэлжлүүлэхгүй:**
- (а) **Хейжийн хэрэглүүрийн хугацаа дууссан, борлуулсан, дуусгавар болгосон эсвэл хэрэгжүүлсэн (Хейжийн хэрэглүүрийг өөр хейжийн хэрэглүүрээр орлуулах буюу солих нь тухайн байгууллагын баримтжуулсан хейжийн стратегийн нэг хэсэг бол**

дээрх зорилгын хувьд хейжийн хэрэглүүрийн сольж, орлуулалтыг түүний хугацаа дуусалт эсвэл дуусгавар болголт гэж үзэхгүй).

- (б) Тухайн хейж нь 98-р параграфт заасан хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг цаашид хангахгүй болсон; эсвэл
- (в) Байгууллага нь хейжийн хэрэглүүрээр сонгохоо больсон.

103. Үр ашигт хүүний аргыг ашигладаг, хейж хийсэн санхүүгийн хэрэглүүрийн дансны үнэд (хүүний түвшний эрсдлийн багц хейжийн хувьд 100-р параграфт заасан, санхүүгийн байдлын тайлан дахь тусдаа мөрийн зүйлд) 99(б) параграфын дагуу хийгдэх аливаа тохируулгыг хорогдуулж, ашиг, алдагдалд тусгана. Тохируулгыг хиймэгц хорогдуулгыг эхлэн тооцож болно, харин уг хейж хийж буй эрсдэлд хамаарах түүний бодит үнэ цэнийн өөрчлөлтийн хувьд хейжийн зүйлийг тохируулахаа болих хугацаанаас өмнө хорогдуулгыг тооцож эхэлсэн байвал зохино. Уг тохируулга нь хорогдуулгыг тооцож эхлэх өдрөөрх дахин тооцоолсон үр ашигт хүүний түвшинд үндэслэнэ. Гэвч санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн багцын хүүний түвшний эрсдэлд хамаарах бодит үнэ цэнийн хейжийн (зөвхөн ийм хейжийн) хувьд, дахин тооцоолсон үр ашигт хүүний түвшинг ашиглан хорогдуулгыг тооцох практик боломжгүй бол шулуун шугамын аргыг ашиглан энэхүү тохируулгын дүнг хорогдуулна. Санхүүгийн хэрэглүүрийн хугацаа дуусахад, харин хүүний түвшний эрсдлийн багц хейжийн хувьд холбогдох хүүний түвшинг дахин хянах хугацаа дуусахад уг тохируулгыг бүрэн хорогдуулсан байвал зохино.

104. Хүлээн зөвшөөрөөгүй арилжааны баталгааг хейжийн зүйл гэж сонгосон тохиолдолд уг хейж хийсэн эрсдэлд хамаарах арилжааны баталгааны бодит үнэ цэнэд гарсан дараагийн тайлант үеийн хуримтлагдсан өөрчлөлтийг хөрөнгө эсвэл өр төлбөр гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд харгалзах олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө (99(б) параграфыг үзнэ үү). Тухайн хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг мөн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

105. Байгууллага нь хөрөнгийг худалдан авах эсвэл өр төлбөрийг хариуцах арилжааны баталгаа гаргасан бөгөөд энэ баталгаа нь бодит үнэ цэнийн хейж дэх хейжийн зүйл байх тохиолдолд тэрхүү хейж хийсэн эрсдэлд хамаарах ба санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрсөн арилжааны баталгааны бодит үнэ цэнийн хуримтлагдсан өөрчлөлтийг тусгахын тулд тухайн байгууллага нь уг арилжааны баталгааг биелүүлсний үр дүн болох хөрөнгө эсвэл өр төлбөрийн анхны дансны үнийг тохируулна.

*Мөнгөн гүйлгээний хейж*

106. **Хэрэв мөнгөн гүйлгээний хейж нь 98-р параграфт заасан нөхцлүүдийг тухайн тайлант үеийн туршид хангасан бол түүнийг дараах байдлаар тайлагнана:**

- (a) **Үр дүнтэй хейж (98-р параграфыг үзнэ үү) гэж тодорхойлсон хейжийн хэрэглүүрийн олз, гарзын тэрхүү хэсгийг цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлангаар дамжуулан цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрөх; ба**
  - (б) **Хейжийн хэрэглүүрийн олз, гарзын үр дүнгүй хэсгийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх.**
107. Арай тодруулбал, мөнгөн гүйлгээний хейжийг дараах байдлаар тайлагнана:
- (a) Хейжийн зүйлтэй холбоотой цэвэр хөрөнгө/өмчийн тусдаа бүрэлдэхүүн хэсгийг доорх дүнгүүдийн (үнэмлэхүй дүнгээр) аль багатай тэнцүү болгон тохируулна:
    - (i) Хейжийн эхлэлийн өдрөөс хойш уг хейжийн хэрэглүүрийн хувьд хуримтлагдсан олз эсвэл гарз; ба
    - (ii) Хейжийн эхлэлийн өдрөөс хойш тухайн хейжийн зүйлээс хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн гүйлгээний бодит үнэ цэнийн (өнөөгийн үнэ цэнийн) хуримтлагдсан өөрчлөлт;
  - (б) Хейжийн хэрэглүүрийн эсвэл түүний сонгосон хэсгийн аливаа үлдсэн олз, гарзыг (энэ нь үр дүнтэй хейж биш) ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө; ба
  - (в) Хейжийн харилцааны талаархи тухайн байгууллагын эрсдлийн удирдлагын баримтжуулсан стратеги нь хейжийн хэрэглүүрийн олз, гарзын эсвэл холбогдох мөнгөн гүйлгээний тодорхой бүрэлдэхүүн хэсгийг хейжийн үр дүнтэй байдлын үнэлгээнд харгалздаггүй бол (83, 84, 98(а) параграфыг үзнэ үү) тэрхүү харгалзан оруулдаггүй олз, гарзын бүрэлдэхүүн хэсгийг 64-р параграфын дагуу хүлээн зөвшөөрнө.
108. **Урьдчилан таамагласан ажил гүйлгээний хейж нь дараагийн тайлант үед санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөр хүлээн зөвшөөрөхөд хүргэдэг бол 106-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн холбогдох олз, гарзыг уг хейж хийсэн урьдчилан таамагласан мөнгөн гүйлгээ нь ашиг, алдагдалд нөлөө үзүүлэх тэрхүү тайлант үед буюу үеүдэд (хүүний орлого эсвэл хүүний зардлыг хүлээн зөвшөөрсөн тайлант үеүд гэх мэт) дахин ангилах залруулга байдлаар ашиг, алдагдалд дахин ангилна. Гэвч цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн бүх буюу зарим гарз нь ирээдүйн нэг болон хэд хэдэн тайлант үеүдэд нөхөгдөхгүй гэж уг байгууллага хүлээж байгаа бол тэрхүү нөхөгдөхөөргүй байгаа дүнг ашиг, алдагдалд дахин ангилна.**
109. **Урьдчилан таамагласан ажил гүйлгээний хейж нь дараагийн тайлант үед санхүүгийн бус хөрөнгө буюу санхүүгийн бус өр төлбөр хүлээн зөвшөөрөхөд хүргэдэг, эсвэл санхүүгийн бус хөрөнгө буюу санхүүгийн бус өр төлбөрийн талаархи урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь арилжааны баталгаа болдог бөгөөд түүнд бодит үнэ**

цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэх бол байгууллага нь доорх (а) эсвэл (б) заалтыг баримтална:

- (а) 106-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн холбогдох олз, гарзыг уг худалдаж авсан хөрөнгө буюу хариуцсан өр төлбөр нь ашиг, алдагдалд нөлөө үзүүлэх тэрхүү тайлант үед буюу үеүдэд (элэгдлийн зардал эсвэл бараа материалыг зардал гэж хүлээн зөвшөөрсөн тайлант үеүд гэх мэт) ашиг, алдагдалд дахин ангилна. Гэвч цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн бүх буюу зарим гарз нь ирээдүйн нэг болон хэд хэдэн тайлант үеүдэд нөхөгдөхгүй гэж уг байгууллага нь хүлээж байгаа бол тэрхүү нөхөгдөхөөргүй байгаа дүнг цэвэр хөрөнгө/өмчөөс ашиг, алдагдалд дахин ангилна.
  - (б) 106-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн холбогдох олз, гарзыг цэвэр хөрөнгө/өмчөөс хасаж, тухайн хөрөнгө, өр төлбөрийн анхны өртөгт буюу бусад адилтгах дансны үнэд тусган оруулна.
110. Байгууллага нь 109-р параграфын (а) эсвэл (б) заалтыг өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлого болгон баримтлах бөгөөд 109-р параграфт хамаарах бүх хейжийн хувьд түүнийг тууштай мөрдөнө.
111. 108 ба 109-р параграфт хамаарахаас бусад, мөнгөн гүйлгээний хейжийн хувьд цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрч байсан дүнгүүдийг уг хейж хийсэн урьдчилан таамагласан мөнгөн гүйлгээ нь ашиг, алдагдалд нөлөө үзүүлэх тэрхүү тайлант үед буюу үеүдэд (жишээлбэл; урьдчилан таамаглаж байсан борлуулалт хийгдсэн үед) ашиг, алдагдалд дахин ангилна.
112. Дараах аль нэг нөхцөл байдалд байгууллага нь 106-111-р параграфт заасан хейжийн нягтлан бодох бүртгэлийг цаашид үргэлжлүүлэхгүй:
- (а) Хейжийн хэрэглүүрийн хугацаа дууссан, борлуулсан, дуусгавар болгосон эсвэл хэрэгжүүлсэн (Хейжийн хэрэглүүрийг өөр хейжийн хэрэглүүрээр орлуулах буюу солих нь тухайн байгууллагын баримтжуулсан хейжийн стратегийн нэг хэсэг бол дээрх зорилгын хувьд хейжийн хэрэглүүрийн сольж, орлуулалтыг түүний хугацаа дуусалт эсвэл дуусгавар болголт гэж үзэхгүй). Ийм тохиолдолд уг хейж үр дүнтэй болсон тайлант үеэс эхлэн цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа, хейжийн хэрэглүүрийн хуримтлагдсан олз, гарз (106(а) параграфыг үзнэ үү) нь тухайн урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдох хүртэл цэвэр хөрөнгө/өмчид тусдаа тусгагдсан хэвээр байна. Уг ажил гүйлгээ гарч тохиолдсон үед 108, 109 эсвэл 111-р параграфыг мөрдөнө.
  - (б) Тухайн хейж нь 98-р параграфт заасан хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг цаашид хангахгүй болсон. Ийм тохиолдолд уг хейж үр дүнтэй болсон тайлант үеэс эхлэн цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа,

хейжийн хэрэглүүрийн хуримтлагдсан олз, гарз (106(a) параграфыг үзнэ үү) нь тухайн урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдох хүртэл цэвэр хөрөнгө/өмчид тусдаа тусгагдсан хэвээр байна. Уг ажил гүйлгээ гарч тохиолдсон үед 108, 109 эсвэл 111-р параграфыг мөрдөнө.

- (в) Урьдчилан таамагласан ажил гүйлгээг цаашид гарч тохиолдоно гэж хүлээхгүй болсон. Ийм тохиолдолд уг хейж үр дүнтэй болсон тайлант үеэс эхлэн цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа, хейжийн хэрэглүүрийн аливаа холбогдох хуримтлагдсан олз, гарзыг (106(a) параграфыг үзнэ үү) ашиг, алдагдалд дахин ангилна. Хэрэгжих өндөр магадлалтай (98(в) параграфыг үзнэ үү) байхаа больсон уг урьдчилан таамагласан ажил гүйлгээг хэрэгжинэ гэж хүлээсэн хэвээр байж болно.
- (г) Байгууллага нь хейжийн хэрэглүүрээр сонгохоо больсон. Урьдчилан таамагласан ажил гүйлгээний хейжийн хувьд, уг хейж үр дүнтэй болсон тайлант үеэс эхлэн цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа, хейжийн хэрэглүүрийн хуримтлагдсан олз, гарз (106(a) параграфыг үзнэ үү) нь тухайн урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдох эсвэл гарч тохиолдоно гэж хүлээхээ болих хүртэл цэвэр хөрөнгө/өмчид тусдаа тусгагдсан хэвээр байна. Уг ажил гүйлгээ гарч тохиолдсон үед 108, 109 эсвэл 111-р параграфыг мөрдөнө. Хэрэв тухайн ажил гүйлгээг гарч тохиолдоно гэж хүлээхээ больсон бол цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн уг хуримтлагдсан олз, гарзыг ашиг, алдагдалд дахин ангилна.

*Цэвэр хөрөнгө оруулалтын хейж*

113. Гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хейжийг, үүн дотроо уг цэвэр хөрөнгө оруулалтын нэг хэсэг байдлаар тайлагнасан мөнгөн зүйлсийн хейжийг (УСНББОУС 4-ийг үзнэ үү) мөнгөн гүйлгээний хейжийн нэгэн адилаар тайлагнана:
- (а) Үр дүнтэй хейж (98-р параграфыг үзнэ үү) гэж тодорхойлсон хейжийн хэрэглүүрийн олз, гарзын тэрхүү хэсгийг цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлангаар (УСНББОУС 1-ийг үзнэ үү) дамжуулан цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрөх; ба
  - (б) Хейжийн хэрэглүүрийн үр дүнгүй хэсгийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх.

Хейжийн үр дүнтэй хэсэгтэй холбоотой бөгөөд цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн уг хейжийн хэрэглүүрийн олз, гарзыг тухайн гадаад үйл ажиллагааг данснаас хасах үед УСНББОУС 4-ийн 56-57-р параграфын дагуу ашиг, алдагдалд дахин ангилна.

## Шилжилтийн нөхцөл

- 114. [Хассан]
- 115. [Хассан]
- 116. [Хассан]
- 117. [Хассан]
- 118. [Хассан]
- 119. [Хассан]
- 120. [Хассан]
- 121. [Хассан]
- 122. [Хассан]
- 123. [Хассан]

## Хүчин төгөлдөр болох хугацаа

- 124. **Байгууллага нь энэхүү Стандартыг 2013 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь энэ Стандартыг 2013 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.**
- 125. **Хэрэв байгууллага нь УСНББОУС 28 ба УСНББОУС 30-ыг бас мөрдөөгүй л бол энэ Стандартыг 2013 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө мөрдөхгүй.**
- 125А. **2011 оны 10 дугаар сард гаргасан УСНББОУС 32, *Үйлчилгээний Концессын Хэлцэл: Эрх бүхий этгээд*-ээр 2-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2014 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2014 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 32, УСНББОУС 5-ын 6 ба 42А параграфын нэмэлт өөрчлөлт, УСНББОУС 13-ын 25-27, 85Б параграфуудын нэмэлт өөрчлөлт, УСНББОУС 17-гийн 5, 7, 107В параграфуудын нэмэлт өөрчлөлт, УСНББОУС 31-ийн 6, 132А параграфын нэмэлт өөрчлөлтийг тус тус даган мөрдөнө.**
- 125Б. **2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын***



**Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх-ийн үр дүнд 114, 115, 116, 117, 118, 119, 120, 121, 122, 124, 126-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед УСНББОУС 33-ыг мөрдсөн бол эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөн тэрхүү өмнөх тайлант үед даган мөрдөнө.**

- 125В. 2015 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 35, *Нэгтгэсэн Санхүүгийн Тайлан* ба УСНББОУС 37, *Хамтын Хэлэлцээр-ийн үр дүнд 2(a), 17, 89, МЗУ2, МЗУ14, МЗУ51-МЗУ53, В2-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь УСНББОУС 35 ба УСНББОУС 37-г мөрдсөн үеэс эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг дагаж мөрдөнө.*
- 125Г. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС 2015-ын Сайжруулалтууд*-аар МЗУ8-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 125Д. 2016 оны 4 дүгээр сард гаргасан *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-аар 8, 8-р параграфуудыг хассан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.
- 125Е. 2016 оны 7 дугаар сард гаргасан УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж-ийн үр дүнд 2-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2018 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 39-ийг мөрдөнө.*
- 125Ж. 2017 оны 01 дүгээр сард гаргасан УСНББОУС 40, *Улсын Секторын Нэгдэл-ийн үр дүнд 2, МЗУ35, МЗУ131, Б4-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019*

**оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн УСНББОУС 40-ийг мөрдөнө.**

126. УСНББОУС 33, *Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх*-д тодорхойлсон, нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт УСНББОУС-ыг байгууллага нь энэхүү хүчин төгөлдөр болох хугацаанаас хойш, санхүүгийн тайлагналын зорилгоор мөрдсөн тохиолдолд УСНББОУС-ыг мөрдсөн өдөр буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамрах уг байгууллагын жилийн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.

## Хавсралт А

### Мөрдөх заавар удирдамж

Энэ Хавсралт нь УСНББОУС 29-ийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.

#### Цар хүрээ (2-8-р параграф)

МЗУ1. Энэхүү Стандарт нь нягтлан бодох бүртгэл ба тайлагналдаа олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартыг мөрддөг тэтгэвэрт гарах үеийн тэтгэмжийн хөтөлбөрийн тайлагнасан ажилтны тэтгэмж, түүнчлэн УСНББОУС 9-ийн дагуу тайлагнадаг борлуулалтын буюу үйлчилгээний орлогын хэмжээнд үндэслэх эрхийн шимтгэлийн гэрээтэй холбоотой шаардлагуудыг өөрчлөхгүй.

*Хяналтанд буй байгууллагууд, Хараат байгууллагууд болон Хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалт*

МЗУ2. Зарим үед байгууллага нь “стратегийн хөрөнгө оруулалт” гэж үзсэн тохиолдолд хөрөнгө оруулалт хүлээн авч буй байгууллагатайгаа урт хугацаанд үйл ажиллагааны харилцаа тогтоох буюу хадгалах зорилгоор түүний гаргасан өмчийн хэрэглүүрт хөрөнгө оруулалт хийдэг. Уг хөрөнгө оруулагч буюу хамтарсан үйлдвэрийн хувь оруулагч байгууллага нь ийм хөрөнгө оруулалтын хувьд нягтлан бодох бүртгэлийн өмчийн аргыг хэрэглэх эсэхийг тодорхойлохын тулд УСНББОУС 36-г харгалзан үзнэ. Хэрэв өмчийн арга тохиромжгүй бол байгууллага нь тэрхүү стратегийн хөрөнгө оруулалтандаа энэ Стандартыг мөрдөнө.

*Даатгалын гэрээ*

МЗУ3. Даатгалын гэрээнээс үүсдэг учраас 2(д) параграфт заасанчлан, цар хүрээнд хамаардаггүй эрх, үүргээс бусад тухайн даатгагчийн санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрт энэ Стандартыг мөрдөнө. Гэвч байгууллага нь дараах зүйлсэд энэ Стандартыг мөрдөхгүй:

- Баталгаа гаргагч нь УСНББОУС 28-ын дагуу даатгалын гэрээ гэж үзэх сонголт хийсэн гэрээнээс бусад, санхүүгийн баталгааны гэрээ; ба
- Даатгалын гэрээнд агуулагдсан дагалдах үүсмэл хэрэглүүр.

Байгууллага нь санхүүгийн эрсдлийн шилжүүлэлтийг агуулсан бусад даатгалын гэрээнд энэ Стандартыг мөрдөж болох боловч заавал мөрдөх албагүй юм.

МЗУ4. Санхүүгийн баталгааны гэрээ нь баталгаа, зарим төрлийн аккредитив, зээлийн үл биелүүлэлтийн гэрээ, даатгалын гэрээ гэх мэт хуулийн янз бүрийн хэлбэртэй байж болно. Ийм гэрээний нягтлан бодох бүртгэлийн хандлага нь тэдгээрийн хуулийн хэлбэрээс хамаарахгүй юм. Тохирох арга хандлагын жишээг доор дурдав (2(д) параграфыг үзнэ үү):

- (а) Хэрэв шилжүүлсэн эрсдэл нь мэдэгдэхүйц их бол санхүүгийн баталгааны гэрээ нь даатгалын гэрээний тодорхойлолтыг хангасан ч гэсэн тухайн гаргагч нь энэ Стандартыг мөрдөнө. Хэрэв гаргагч нь санхүүгийн баталгааны гэрээг даатгалын гэрээ гэж үзэх нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өмнө нь мөрдөж байсан бөгөөд даатгалын гэрээнд мөрдөж болох нягтлан бодох бүртгэлийг ашиглаж байсан бол уг байгууллага нь зарим нөхцөл байдалд санхүүгийн баталгааны гэрээг УСНББОУС 28-ын дагуу санхүүгийн хэрэглүүрийн даатгалын гэрээ гэж үзэх сонголтыг ямартаа ч хийж болох бөгөөд тухайн гаргагч нь ийм санхүүгийн баталгааны гэрээнд энэ Стандарт эсвэл даатгалын гэрээнд хамаарах олон улсын буюу үндэсний нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартын аль нэгийг мөрдөх сонголт хийж болно. Хэрэв энэ Стандартыг мөрдөх бол 45-р параграфт шаардсаны дагуу, уг гаргагч нь санхүүгийн баталгааны гэрээг анх түүний бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрнө. Хэрэв санхүүгийн баталгааны гэрээг харилцан хамааралгүй талуудын нэг тусдаа ажил гүйлгээгээр холбоогүй талд гарган өгсөн бол тэрхүү анх гаргах үед түүний бодит үнэ цэнэ нь эсрэг нотолгоотой байхаас бусад тохиолдолд тухайн хүлээн авсан урамшууллын дүнтэй тэнцүү байна. Тухайн санхүүгийн баталгааны гэрээг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж анх ангилсан эсвэл 31-39-р параграф болон МЗУ62-МЗУ67-р параграфыг мөрдсөнөөс бусад тохиолдолд (санхүүгийн хөрөнгийн шилжүүлэлт нь үл хүлээн зөвшөөрөх эсвэл цаашдын оролцооны арга хандлагыг мөрдөх шалгуурыг хангахгүй тохиолдолд) уг гаргагч нь түүнийг дараагийн тайлант үеүдэд дараах хоёр дүнгийн аль өндрөөр хэмжинэ:
- (i) УСНББОУС 19-ийн дагуу тодорхойлсон дүн; ба
  - (ii) Анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс хэрэв тохиромжтой бол УСНББОУС 9-ийн дагуу хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан хорогдуулгыг хассан дүн (49(в) параграфыг үзнэ үү).
- (б) Зээлтэй холбоотой зарим баталгаа нь энэхүү баталгааг эзэмшигч эрсдэлд өртөх ба уг баталгаа гаргасан хөрөнгийн хувьд хугацаа болсон төлбөрийг зээлдэгч төлөөгүйн улмаас гарз учирсан байхыг төлбөрийн урьдчилсан нөхцөл болгон шаарддаггүй. Ийм баталгааны жишээ нь тохиролцсон зээлийн зэрэглэл буюу зээлийн индексийн өөрчлөлтийн хариу болгон төлбөр хийхийг шаарддаг баталгаа юм. Ийм баталгаа нь энэ Стандартад тодорхойлсон санхүүгийн баталгааны гэрээ биш, мөн даатгалын гэрээ ч биш юм. Ийм баталгаа нь үүсмэл хэрэглүүр бөгөөд гаргагч нь түүний хувьд энэ Стандартыг мөрдөнө.
- (в) Хэрэв санхүүгийн баталгааны гэрээг барааны борлуулалттай холбоотойгоор гаргасан бол гаргагч нь уг баталгааны болон бараа борлуулалтын орлогыг хэзээ хүлээн зөвшөөрөх эсэхийг тодорхойлохдоо УСНББОУС 9-ийг мөрдөнө.

МЗУ5. Зарим гэрээ нь уур амьсгалын, геологийн болон бусад биет хувьсагчдад үндэслэн төлбөр хийхийг шаарддаг. (Уур амьсгалын хувьсагчдад үндэслэдэг төлбөр бүхий гэрээг зарим үед “цаг агаарын үүсмэл хэрэглүүр” гэж нэрлэдэг.) Хэрэв ийм гэрээ нь даатгалын гэрээ биш бол энэ Стандартын цар хүрээнд хамаарна.

*Арилжааны бус орлогын ажил гүйлгээнээс үүссэн эрх ба үүрэг*

МЗУ6. Эрх ба үүрэг (хөрөнгө ба өр төлбөр) нь арилжааны бус орлогын ажил гүйлгээнээс үүсэж болно. Жишээлбэл; байгууллага нь тодорхой үйл ажиллагаа явуулахын тулд олон улсын агентлагаас мөнгө хүлээн авч болно. Эдгээр үйл ажиллагааны гүйцэтгэл нь нөхцөлд захирагдах учраас хөрөнгө, өр төлбөрийг нэгэн зэрэг хүлээн зөвшөөрнө. Хөрөнгө нь санхүүгийн хөрөнгө бол түүнийг УСНББОУС 23-ын дагуу хүлээн зөвшөөрч, энэ Стандарт ба УСНББОУС 23-ын дагуу анх хэмжинэ. Тухайн хөрөнгийн ашиглалтанд тавигдсан нөхцлийн улмаас анх хүлээн зөвшөөрсөн өр төлбөр нь энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй бөгөөд түүнийг УСНББОУС 23-ын дагуу тайлагнана. УСНББОУС 23-ын дагуу өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх нь цаашид тохиромжгүй гэдгийг анхны хүлээн зөвшөөрөлтийн дараах нөхцөл байдал илэрхийлж байвал байгууллага нь уг санхүүгийн өр төлбөрийг энэхүү Стандартын дагуу хүлээн зөвшөөрөх эсэхийг харгалзан үзнэ. Арилжааны бус орлогын ажил гүйлгээнээс үүсэж болох бусад өр төлбөр нь УСНББОУС 28-д заасан санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангаж байвал тэдгээрийг энэ Стандартын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжинэ.

## **Тодорхойлолт (9 ба 10-р параграф)**

*Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэсэн ангилал*

МЗУ7. Санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөр эсвэл санхүүгийн хэрэглүүрүүдийн бүлгийг (санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөр эсвэл эдгээрийн аль алиныг) ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилах нь илүү хамааралтай мэдээллээр хангах үр дүнтэй байвал байгууллага нь ингэж ангилахыг энэ Стандартын 10-р параграфээр зөвшөөрдөг.

МЗУ8. Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилах тухайн байгууллагын сонголт нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын сонголттой ижил төсөөтэй байдаг (гэвч нягтлан бодох бүртгэлийн бодлогын сонголтлоос ялгаатай нь ийм сонголтыг ижил төсөөтэй бүх ажил гүйлгээнд тууштай мөрдөхийг заавал шаарддаггүй). Байгууллага нь бодлогын ийм сонголт хийсэн тохиолдолд тухайн сонгосон бодлого нь уг байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээнд ажил гүйлгээ, бусад үйл явдал болон нөхцөл байдлын үзүүлэх үр нөлөөний талаархи найдвартай бөгөөд илүү хамааралтай мэдээллийг тухайн санхүүгийн тайланд бий болгох үр дүнтэй байхыг УСНББОУС 3, *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын*

*Өөрчлөлт ба Алдаа*-ны 17(б) параграфтаар шаарддаг. Тухайлбал; санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилах тохиолдолд илүү хамааралтай мэдээллийн талаархи шаардлага хангагдах хоёр нөхцлийг 10-р параграфт заасан байдаг. Иймээс 10-р параграфын дагуу ийм ангилал хийхээр сонгохын тулд байгууллага нь эдгээр хоёр нөхцлийн аль нэгийг (эсвэл хоёуланг нь) хангасан гэдгээ батлан харуулах шаардлагатай юм.

**Стандартын 10(б)(i) параграф: Үүсэх байсан хэмжилтийн буюу хүлээн зөвшөөрөлтийн тууштай бус байдлыг арилгах буюу мэдэгдэхүйц бууруулах ангилал**

МЗУ9. УСНББОУС 29-ийн дагуу санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн хэмжилт болон тэдгээрийн үнэ цэнийн хүлээн зөвшөөрсөн өөрчлөлтийн ангиллыг тухайн зүйлийн ангиллаар, түүнчлэн уг зүйл нь сонгосон хейжийн харилцааны нэг хэсэг эсэхээр тодорхойлдог. Энэ шаардлага нь хэмжилтийн эсвэл хүлээн зөвшөөрөлтийн тууштай бус байдлыг (зарим үед “нягтлан бодох бүртгэлийн уялдаагүй байдал” гэж нэрлэдэг) үүсгэж болох юм. Жишээлбэл; ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилаагүй тохиолдолд уг санхүүгийн хөрөнгийг борлуулах боломжтой гэж ангилах болсон (бодит үнэ цэнийн ихэнх өөрчлөлтийг цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрснөөр) ба тэрхүү санхүүгийн хөрөнгөтэй холбоотой гэж байгууллагын үзэж буй өр төлбөрийг (бодит үнэ цэнийн өөрчлөлтүүдийг хүлээн зөвшөөрөхгүйгээр) хорогдуулсан өртгөөр хэмжсэн. Ийм тохиолдолд байгууллага нь тэдгээр хөрөнгө, өр төлбөрийн аль алиныг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн бол илүү хамааралтай мэдээллийг түүний санхүүгийн тайланд тусган илэрхийлэх байсан гэж үзэж болох юм.

МЗУ10. Ийм нөхцөл хэзээ үүсэж болохыг дараах жишээнд харуулав. 10(б)(i) параграфт дурдсан зарчим зөвхөн хангагдаж байвал байгууллага нь санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилахын тулд энэхүү нөхцлийг дараах бүх тохиолдолд ашиглаж болно:

- (а) Байгууллага нь борлуулах боломжтой гэж ангилах байсан хөрөнгийн гүйцэтгэлд гэрээний дагуу мөнгөн гүйлгээ нь үндэслэдэг өр төлбөртэй байх. Жишээлбэл; даатгагч нь түүний хөрөнгүүдийн тусгай нэгдлийн хүлээн зөвшөөрсөн ба/буюу хүлээн зөвшөөрөөгүй хөрөнгө оруулалтын өгөөжид үндэслэн өгөөжийг төлдөг, сонголттой оролцох шинж бүхий өр төлбөртэй байж болно. Хэрэв тэдгээр өр төлбөрийн хэмжилт нь одоогийн зах зээлийн үнийг тусгадаг бол уг хөрөнгийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилах нь өр төлбөрийн үнэ цэнийн холбогдох өөрчлөлттэй адилаар тэрхүү санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийг тухайн тайлант үед ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө гэсэн үг юм.
- (б) Байгууллага нь даатгалын гэрээний дагуу үүссэн ба түүний хэмжилтэнд одоогийн мэдээллийг нэгтгэн тусгадаг өр төлбөртэй

бөгөөд түүнтэй холбоотой гэж үзсэн, харин үүнээс өөр тохиолдолд борлуулах боломжтой гэж ангилах эсвэл хорогдуулсан өртгөөр хэмжих байсан санхүүгийн хөрөнгөтэй байх.

- (в) Байгууллага нь хүүний түвшний эрсдэл гэх мэт эрсдлийг хуваалцдаг бөгөөд бие биенийгээ харилцан нөхөх хандлагатайгаар бодит үнэ цэнийн эсрэг тэсрэг өөрчлөлтийг бий болгодог санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөртэй эсвэл тэдгээрийн аль алинтай байх. Гэвч зөвхөн зарим хэрэглүүрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг (жишээлбэл; үүсмэл хэрэглүүр болох эсвэл худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж ангилсан зүйлс) байх. Тухайлбал, 98-р параграфт заасан хейжийн үр дүнтэй байдлын шаардлага хангагдаагүйн улмаас хейжийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагыг хангахгүй бол мөн ийм тохиолдол үүсэж болох юм.
- (г) Байгууллага нь хүүний түвшний эрсдэл гэх мэт эрсдлийг хуваалцдаг, бие биенийгээ харилцан нөхөх хандлагатайгаар бодит үнэ цэнийн эсрэг тэсрэг өөрчлөлтийг бий болгодог санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөртэй эсвэл тэдгээрийн аль алинтай бөгөөд аль ч хэрэглүүр нь үүсмэл биш учраас тухайн байгууллага нь хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангахгүй байх. Түүнчлэн, хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглээгүй үед олз, гарзын хүлээн зөвшөөрөлтөнд мэдэгдэхүйц тууштай бус байдал үүсдэг. Жишээлбэл;
- (i) Байгууллага нь борлуулах боломжтой гэж ангилах байсан тогтмол хүүтэй хөрөнгүүдийн багцыг бодит үнэ цэнийн өөрчлөлтөөрөө бие биенийгээ харилцан нөхөх хандлагатай, тогтмол хүүтэй өрийн бичгээр санхүүжүүлэх. Хөрөнгө ба өрийн бичгийн аль алиныг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр тайлагнах нь бодит үнэ цэнийн өөрчлөлтийг цэвэр хөрөнгө/өмчид тайлагнаснаар хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмжих ба өрийн бичгийг хорогдуулсан өртгөөр хэмжсэнээр үүсэх байсан тууштай бус байдлыг засварладаг.
- (ii) Байгууллага нь бодит үнэ цэнийн өөрчлөлтөөрөө бие биенийгээ харилцан нөхөх хандлагатай бонд гаргах замаар зээлийн тодорхой бүлгийг санхүүжүүлэх. Мөн түүнчлэн, байгууллага нь бондыг байнга худалдан авч, борлуулдаг боловч зээлийг бараг худалдан авч, борлуулдаггүй бол тэдгээр зээл, бондын аль алиныг өөр бусад тохиолдолд хорогдуулсан өртгөөр хэмжиж, бондыг буцаан худалдан авах үед олз, гарзыг хүлээн зөвшөөрөх байсан бөгөөд харин уг зээл, бондын аль алиныг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр тайлагнаснаар олз, гарзын хүлээн зөвшөөрөлтийн хугацааны ийм тууштай бус байдлыг арилгах юм.

M3Y11. Өөр бусад тохиолдолд ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилахгүй байсан санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг өмнөх параграфт дурдсантай адил гэх мэт нөхцөл байдалд

анх хүлээн зөвшөөрөхдөө ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилах нь хэмжилт болон хүлээн зөвшөөрөлтийн тууштай бус байдлыг арилгах буюу мэдэгдэхүйц бууруулах ба илүү хамааралтай мэдээлэл бий болоход хүргэж болох юм. Практик зорилгын хувьд байгууллага нь хэмжилт буюу хүлээн зөвшөөрөлтийн тууштай бус байдлыг үүсгэх хөрөнгө, өр төлбөрийн бүх ажил гүйлгээг яг нэг ижил хугацаанд хийсэн байх албагүй юм. Ажил гүйлгээ бүрийг анх хүлээн зөвшөөрөхдөө ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилдаг бөгөөд үлдсэн аливаа ажил гүйлгээнүүд нь гарч тохиолдоно гэж хүлээж байгаа бол зохих ёсоор хойшлуулахыг зөвшөөрдөг.

- МЗУ12. Тууштай бус байдлыг үүсгэдэг санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийн зөвхөн зарим хэсгийг нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилах нь тэрхүү тууштай бус байдлыг арилгадаггүй эсвэл мэдэгдэхүйц бууруулдаггүй, иймээс илүү хамааралтай мэдээлэл бий болгодоггүй бол тэрхүү санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийн зарим хэсгийг ингэж ангилахыг зөвшөөрөхгүй. Харин ижил төсөөтэй, олон санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн зөвхөн зарим хэсгийг ингэж ангилах нь уг тууштай бус байдлыг мэдэгдэхүйц бууруулж байвал (хүлээн зөвшөөрч болох бусад ангилалуудаас илүү их хэмжээгээр бууруулах боломжтой бол) ингэж ангилахыг зөвшөөрнө. Жишээлбэл; байгууллага нь 100ТН<sup>4</sup>-ийн үнийн дүн бүхий ижил төсөөтэй, олон санхүүгийн өр төлбөртэй ба 50ТН-ийн үнийн дүн бүхий ижил төсөөтэй, олон санхүүгийн хөрөнгөтэй боловч тэдгэрийг өөр өөр сууриар хэмждэг гэж үзье. Тухайн байгууллага нь анх хүлээн зөвшөөрөх үедээ тэдгээр хөрөнгийг бүгдийг нь, харин өр төлбөрийн зөвхөн зарим хэсгийг (жишээлбэл; нийт 45ТН-ийн дүн бүхий тусдаа өр төлбөрүүдийг) нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилснаар уг хэмжилтийн тууштай бус байдлыг мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулж болох юм. Гэхдээ ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэсэн ангиллыг тухайн санхүүгийн хэрэглүүрт бүхэлд нь зөвхөн хэрэглэж болох учраас энэ жишээнд байгууллага нь нэг буюу хэд хэдэн өр төлбөрийг бүхэлд нь ингэж ангилах ёстой. Харин өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсгийг (жишээлбэл; бенчмарк хүүний түвшний өөрчлөлт гэх мэт зөвхөн нэг эрсдэлд хамааруулж болох үнэ цэнийн өөрчлөлт) эсвэл тодорхой нэг хэсгийг (өөрөөр хэлбэл, хувийн жинг) ингэж ангилж болохгүй.

**10(б)(ii) параграф: Эрсдлийн удирдлагын болон хөрөнгө оруулалтын баримтжуулсан стратегийн дагуу удирдаж, түүний гүйцэтгэлийг бодит үнэ цэнийн сууриар үнэлдэг санхүүгийн хөрөнгүүдийн бүлэг, санхүүгийн өр төлбөрүүдийн бүлэг эсвэл эдгээрийн аль алины бүлэг**

- МЗУ13. Санхүүгийн хөрөнгүүдийн бүлэг, санхүүгийн өр төлбөрүүдийн бүлэг эсвэл эдгээрийн аль алины бүлгийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих нь илүү хамааралтай мэдээлэл бий болгох тийм арга

<sup>4</sup> Энэ Стандартад мөнгөн дүнг “тооцооны нэгж” (ТН) гэж тэмдэглэсэн.



замаар байгууллага нь уг бүлгийг удирдан зохицуулж, гүйцэтгэлийг үнэлдэг. Энэ тохиолдолд гол анхаарах зүйл нь санхүүгийн хэрэглүүрийн өөрийн шинж төрөл биш, харин тухайн байгууллага түүнийг удирдан зохицуулж, гүйцэтгэлийг үнэлж буй арга зам юм.

МЗУ14. Ийм нөхцөл хэзээ үүсэж болохыг дараах жишээнд харуулав. 10(б)(i) параграфт дурдсан зарчим зөвхөн хангагдаж байвал байгууллага нь санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилахын тулд энэхүү нөхцлийг дараах бүх тохиолдолд ашиглаж болно:

- (а) Байгууллага нь хүү, ногдол ашиг буюу түүнтэй адилтгах хуваарилалт, бодит үнэ цэнийн өөрчлөлт хэлбэрийн нийт өгөөжөөс ашиг олох зорилготойгоор санхүүгийн хөрөнгөнд хөрөнгө оруулалт хийх бизнес эрхэлдэг хувийн капиталт байгууллага, хамтын сан, нэгжийн итгэмжлэлийн сан буюу түүнтэй ижил төсөөтэй байгууллага юм. Ийм хөрөнгө оруулалтыг энэ Стандартын дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжихийг УСНББОУС 36-гаар зөвшөөрсөн байдаг. Байгууллага нь нийт өгөөжийн сууриар удирдан зохицуулдаг бусад хөрөнгө оруулалтанд энэхүү нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдөж болох боловч түүнд үзүүлэх нөлөөлөл нь мэдэгдэхүйц бус бол УСНББОУС 36-гийн цар хүрээнд хамруулна.
- (б) Байгууллага нь нэг буюу хэд хэдэн эрсдлийг хуваалцдаг санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөртэй бөгөөд түүний хөрөнгө, өр төлбөрийн удирдлагын баримтжуулсан бодлогын дагуу тэдгээр эрсдлийг бодит үнэ цэнийн сууриар удирдан зохицуулж, үнэлдэ. Үүний нэг жишээ нь; дагалдах олон үүсмэл хэрэглүүрийг агуулсан ‘нийлмэл бүтээгдэхүүн’<sup>5</sup>-ийг гаргасан бөгөөд түүний үр дүн болох эрсдлүүдийг үүсмэл ба үүсмэл бус санхүүгийн хэрэглүүрүүдийн хольцыг ашигласнаар бодит үнэ цэнийн сууриар удирдан зохицуулдаг байгууллага байж болно. Адилтгах өөр нэг жишээ нь тогтмол хүүтэй зээлийг гаргасан бөгөөд түүний үр дүн болох бенчмарк хүүний түвшний эрсдлийг үүсмэл ба үүсмэл бус санхүүгийн хэрэглүүрүүдийн хольцыг ашигласнаар удирдан зохицуулдаг байгууллага байж болно.
- (в) Байгууллага нь санхүүгийн хөрөнгийн багцыг эзэмшдэг даатгагч бөгөөд багцын нийт өгөөжийг (өөрөөр хэлбэл, хүү, ногдол ашиг

<sup>5</sup> Structured product-Нийлмэл бүтээгдэхүүн гэдэг нь нэг үнэт цаас, үнэт цаасны сагс, опцион, индекс, хэрэглээний бараа, өр, гадаад валют гэх мэт нэг буюу хэд хэдэн үүсмэл хэрэглүүрт үндэслэсэн санхүүгийн хэрэглүүр юм. АНУ-ын Үнэт Цаас Арилжааны Комиссын Дүрэм 134-д нийлмэл бүтээгдэхүүнийг “мөнгөн гүйлгээний шинж байдал нь нэг буюу хэд хэдэн индекс үзүүлэлтүүдээс хамаардаг үнэт цаас буюу түүний хөрөнгө оруулагчийн өгөөж ба гаргагчийн төлөх төлбөр нь суурь хөрөнгүүдийн үнэ цэнэ, индекс, хүүний түвшин, мөнгөн гүйлгээний өөрчлөлтөөс нөхцөлт хамааралтай буюу өндөр мэдрэмжтэй байх “дагалдах форвард гэрээ” эсвэл опцион эсвэл үнэт цаас юм” гэж тодорхойлсон байна. Харин “дагалдах форвард” гэдэг нь холимог хэрэглүүрийн өмчийн шинжийг илэрхийлэх санхүүгийн хэрэглүүр юм. Ред.Ч.Д.

буюу адилтгах хуваарилалт, бодит үнэ цэнийн өөрчлөлт) хамгийн их болгох байдлаар түүнийг удирдан зохицуулж, уг сууриар багцын гүйцэтгэлийг үнэлдэг. Тодорхой өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч эсвэл эдгээийн аль алины баталгаа болгон багцыг эзэмшиж болно. Хэрэв тодорхой өр төлбөрийн баталгаа болгон багцыг эзэмшиж байгаа бол даатгагч нь тухайн өр төлбөрийг бодит үнэ цэнийн сууриар бас удирдан зохицуулж, үнэлдэг эсэхээс үл хамааран 10(б)(ii) параграфын нөхцөл хангагдаж болох юм. Оролцоот гэрээний эзэмшигчдэд төлөх дүн нь богино хугацаанд (жишээлбэл; нэг жилд) хэрэгжсэн олзын дүн гэх мэт бусад хүчин зүйлсээс хамаардаг эсвэл даатгагчийн сонголтоос хамаардаг байлаа ч гэсэн тухайн даатгагчийн зорилго нь уг хөрөнгийн нийт өгөөжийг урт хугацаанд хамгийн их болгох явдал байх тохиолдолд 10(б)(ii) параграфт заасан нөхцөл хангагдаж болох юм.

МЗУ15. Дээр дурдсанчлан, энэ нөхцөл нь уг харгалзан үзэж буй санхүүгийн хэрэглүүрүүдийн бүлгийн гүйцэтгэлийг тухайн байгууллага удирдан зохицуулж, үнэлдэг арга замаас хамаардаг. Иймээс (анх хүлээн зөвшөөрөх үеийн ангиллын шаардлагын дагуу) энэхүү нөхцөлд үндэслэн санхүүгийн хэрэглүүрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилдаг байгууллага нь хамтад нь удирдан зохицуулж, үнэлдэг бүх зохих санхүүгийн хэрэглүүрийг ингэж ангилна.

МЗУ16. Байгууллагын стратегийн баримтжуулалт нь хэт дэлгэрэнгүй байх шаардлагагүй боловч 10(б)(ii) параграфтай нийцэж буй эсэхийг батлан харуулахад хангалттай байвал зохино. Ийм баримтжуулалтыг бие даасан зүйл тус бүрээр хийх шаардлагагүй боловч багцын сууриар хийгдсэн байж болох юм. Жишээлбэл; байгууллагын эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөн баталсанчлан, тухайн байгууллагын хүрээн дэх гүйцэтгэлийн удирдлагын систем нь түүний гүйцэтгэлийг нийт өгөөжийн сууриар үнэлдэг гэдгийг тодорхой харуулдаг бол 10(б)(ii) параграфтай нийцсэн эсэхийг батлан харуулахын тулд цаашдын баримтжуулалт хийх шаардлагагүй юм.

#### *Үр ашигт хүүний арга*

МЗУ17. Зарим тохиолдолд, учирсан зээлийн алдагдлыг тусгах тийм өндөр хөнгөлөлттэй дүнгээр санхүүгийн хөрөнгийг худалдан авдаг. Үр ашигт хүүний түвшинг тооцоолох үедээ байгууллагууд нь ийм учирсан зээлийн алдагдлыг уг тооцоолсон мөнгөн гүйлгээнд тусган оруулдаг.

МЗУ18. Үр ашигт хүүний аргыг хэрэглэх үедээ байгууллага нь аливаа хураамж, төлсөн эсвэл хүлээн авсан оноо, ажил гүйлгээний зардал, түүнчлэн уг үр ашигт хүүний тооцоололд багтсан бусад урамшуулал буюу хөнгөлөлтийг ихэвчлэн тухайн санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацаанд хорогдуулдаг. Гэвч тэдгээр хураамж, төлсөн эсвэл хүлээн авсан оноо, ажил гүйлгээний зардал, урамшуулал буюу хөнгөлөлтийн хамаарах хугацаа нь санхүүгийн хэрэглүүрийн хугацаанаас богино бол тэрхүү богино хугацаанд хорогдуулна. Хураамж, төлсөн эсвэл хүлээн авсан оноо, ажил гүйлгээний зардал, урамшуулал буюу хөнгөлөлтийн хамаарах

хувьсагчийг уг санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй дуусгавар болох хугацаанаас өмнө зах зээлийн түвшнээр дахин үнэлэн тогтоодог бол ийм тохиолдол үүсэж болно. Ингэж тохиолдолд зохих хорогдуулгын хугацаа нь дараагийн дахин үнэ тогтоох өдөр хүртэлх хугацаа байна. Жишээлбэл; хөвөгч хүүтэй санхүүгийн хэрэглүүрийн урамшуулал буюу хөнгөлөлт нь хүүг хамгийн сүүлд төлснөөс хойш тухайн санхүүгийн хэрэглүүрийн хувьд хуримтлагдсан хүүг, эсвэл уг хөвөгч хүүг зах зээлийн түвшнээр дахин тогтоосноос хойш зах зээлийн түвшинд гарсан өөрчлөлтийг тусгадаг бол хөвөгч хүүг зах зээлийн түвшнээр дахин тогтоох дараагийн өдөр хүртэлх хугацаанд урамшуулал, хөнгөлөлтийг хорогдуулна. Яагаад гэвэл, урамшуулал буюу хөнгөлөлтийн хамаарах хувьсагчийг (өөрөөр хэлбэл, хүүний түвшинг) тэрхүү өдөр зах зээлийн түвшнээр тогтоодог тул уг урамшуулал буюу хөнгөлөлт нь хүүг дахин тогтоох дараагийн өдөр хүртэлх хугацаанаас хамаардаг. Харин урамшуулал буюу хөнгөлөлт нь тухайн санхүүгийн хэрэглүүрт заасан хөвөгч хүүний зээлийн тархалтын<sup>6</sup> өөрчлөлтөөс эсвэл зах зээлийн түвшнээр дахин тогтоодоггүй бусад хувьсагчдын үр дүн бол урамшуулал, хөнгөлөлтийг тэрхүү санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацаанд хорогдуулна.

МЗУ19. Хөвөгч хүүтэй санхүүгийн хөрөнгө ба хөвөгч хүүтэй санхүүгийн өр төлбөрийн хувьд зах зээлийн хүүний түвшинд гарсан өөрчлөлтийг тусгах үүднээс хийх мөнгөн гүйлгээний үечилсэн дахин тооцоолол нь уг үр ашигт хүүний хувийг өөрчилдөг. Хөвөгч хүүтэй санхүүгийн хөрөнгө буюу хөвөгч хүүтэй санхүүгийн өр төлбөрийг тэдгээрийн дуусгавар болох өдрөөрх авлага, өглөгийн үндсэн дүнтэй тэнцүү дүнгээр анх хүлээн зөвшөөрдөг бол ирээдүйн хүүний төлбөрүүдийн дахин тооцоолол нь тухайн хөрөнгө буюу өр төлбөрийн дансны үнэд ихэвчлэн мэдэгдэхүйц үр нөлөөгүй байдаг.

МЗУ20. Байгууллага нь мөнгөн орлого буюу төлбөрийн талаархи өөрийн тооцооллыг хянан засварладаг бол тухайн байгууллага нь бодит гүйцэтгэлийн болон хянан засварлаж, тооцоолсон гэрээний мөнгөн гүйлгээг тусгахын тулд уг санхүүгийн хөрөнгийн дансны үнэ буюу санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртгийг (эсвэл санхүүгийн хэрэглүүрүүдийн бүлгийн) тохируулна. Байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн анхны үр ашигт хүүний хувиар, эсвэл хамааралтай тохиолдолд 103-р параграфын дагуу тооцоолсон, хянан засварласан үр ашигт хүүний хувиар дискаунтчилсан, уг тооцоолсон ирээдүйн гэрээний мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээр тухайн санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнийг дахин тооцоолно. Энэхүү тохируулгыг орлого эсвэл

<sup>6</sup> Credit spread-Зээлийн тархалт. Credit spread-Зээлийн тархалт гэдэг нь АНУ-ын Төрийн сангийн бондын өгөөж ба түүнээс чанар муутай боловч ижил дуусгавар болох хугацаатай өрийн үнэт цаасны өгөөж хоорондох зөрүү юм. АНУ-ын Төрийн сангаас гаргасан үнэт цаас нь эрсдэлгүй байдаг тул санхүүгийн зах зээлд түүнийг бенчмарк (стандарт) хэмжигдэхүүн болгон ашигладаг. Өрийн үнэт цаас гаргагч төлбөрөө үл барагдуулах эрсдэл их байхын хирээр түүний үнэт цаасны зээлийн тархалт их байдаг. Зээлийн тархалтыг хувиар биш, тоон дүнгээр илэрхийлдэг. Жишээлбэл; АНУ-ын Төрийн сангийн бондын хүү жилд 4%, үнэт цаас гаргаж буй компанийн санхүүгийн хэрэглүүрийн хүү жилд 7.5% гэвэл, зээлийн тархалт нь 350 болно. Ред.Ч.Д.

зардал байдлаар ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Хэрэв санхүүгийн хөрөнгийг 55, 57, 58-р параграфын дагуу дахин ангилдаг бөгөөд байгууллага нь тэдгээр мөнгөн орлогын нэмэгдсэн нөхөлтийн үр дүнд ирээдүйн мөнгөн орлогын талаархи өөрийн тооцооллыг дараагийн тайлант үед нэмэгдүүлдэг бол уг нэмэгдэлтийн үр нөлөөг тэрхүү тооцооллын өдрөөр хөрөнгийн дансны үнийн тохируулга байдлаар биш, харин тооцооллын өөрчлөлтийн өдрөөс эхлэн тухайн үр ашигт хүүний тохируулга байдлаар хүлээн зөвшөөрнө.

#### Үүсмэл хэрэглүүр

- МЗУ21. Үүсмэл хэрэглүүрийн нийтлэг жишээ нь фьючерс, форвард, своп, опционы гэрээ юм. Үүсмэл хэрэглүүр нь ихэвчлэн нэрлэсэн дүнтэй байдаг. Энэ нь валютын дүн, хувьцааны тоо, жин, эзлэхүүн буюу гэрээнд тусгайлан заасан бусад нэгжийн тоо байна. Гэхдээ үүсмэл хэрэглүүр нь гэрээний эхэн дэх уг нэрлэсэн дүнгээр хөрөнгө оруулах буюу хүлээн авахыг эзэмшигч эсвэл гаргагчаас шаарддаггүй. Харин үүсмэл хэрэглүүр нь тогтмол дүнг эсвэл нэрлэсэн дүнтэй хамааралгүй ирээдүйн зарим үйл явдлын үр дүнд өөрчлөгдөж болох (гэхдээ суурь хэрэглүүрийн өөрчлөлттэй шууд хамараалгүй байдлаар) дүнг төлөхийг шаарддаг. Жишээлбэл; 6 сарын ЛИБОР хүү нь 100 суурь оноогоор нэмэгдвэл 1,000ТН<sup>7</sup>-ийн тогтмол төлбөр хийхийг гэрээгээр шаарддаг байж болох юм. Хэдийгээр нэрлэсэн дүнг тусгайлан заагаагүй боловч ийм гэрээ нь үүсмэл хэрэглүүр болно.
- МЗУ22. Энэ Стандарт дахь үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт нь суурь хэрэглүүрийг нийлүүлснээр нийт дүнгээр барагдуулах гэрээг (жишээлбэл; тогтмол хүүтэй өрийн хэрэглүүрийг худалдан авахын тулд байгуулсан форвард гэрээ) өөртөө агуулсан байдаг. Байгууллага нь цэвэр дүнгээр нь мөнгөөр буюу бусад санхүүгийн хэрэглүүрээр барагдуулах эсвэл санхүүгийн хэрэглүүрээр солилцож болох санхүүгийн бус зүйлийг худалдан авах буюу борлуулах гэрээтэй (жишээлбэл; бараа бүтээгдэхүүнийг тогтмол үнээр ирээдүйд худалдан авах буюу борлуулах гэрээтэй) байж болно. Тухайн байгууллагын хүлээгдэж буй худалдан авалт, борлуулалт буюу ашиглалтын шаардлагуудын дагуу санхүүгийн бус зүйлийг өгөх зорилгоор уг гэрээг байгуулсан ба тэр зорилгоор үргэлжлүүлэн эзэмшиж байгаагаас бусад тохиолдолд ийм гэрээ нь энэхүү Стандартын цар хүрээнд хамаарна (4-6-р параграфыг үзнэ үү).
- МЗУ23. Үүсмэл хэрэглүүрийг тодорхойлох нэг шинж чанар нь зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөнд ижил төсөөтэй хариу үзүүлэхээр хүлээгдэж буй бусад төрлийн гэрээний хувьд шаардагдах байснаас бага хэмжээний анхны цэвэр хөрөнгө оруулалттай байдаг явдал юм. Опционы төлбөр нь уг опционтой холбоотой суурь санхүүгийн хэрэглүүрийг олж авахад шаардагдах хөрөнгө оруулалтаас бага дүнтэй байх тул опционы гэрээ нь энэ тодорхойлолтыг хангана. Тэнцүү бодит үнэ цэнэ бүхий өөр өөр

---

<sup>7</sup> Энэ Стандартад мөнгөн дүнг “тооцооны нэгж” (ТН) гэж тэмдэглэсэн.

валютын анхны арилжааг шаардах валютын своп нь тэг анхны цэвэр хөрөнгө оруулалттай байдаг учраас энэ тодорхойлолтыг хангана.

- МЗУ24. Ердийн нөхцлөөр хийгдэх худалдан авалт буюу борлуулалт нь арилжааны өдөр ба барагдуулалтын өдрийн хооронд тогтмол үнийн баталгаа үүсэхэд хүргэдэг бөгөөд уг баталгаа нь үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолтыг хангадаг. Гэвч тэрхүү баталгааны үргэлжлэх хугацаа богино байдгаас хамааран түүнийг үүсмэл санхүүгийн хэрэглүүр гэж хүлээн зөвшөөрдөггүй. Харин ийм ердийн нөхцөлтэй гэрээний тусгай тайлагналыг энэхүү Стандартад заасан байдаг (40-р параграф болон МЗУ68-МЗУ71-р параграфыг үзнэ үү).
- МЗУ25. Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт нь уг гэрээний аль нэг талд тусгайлан хамаарахгүй санхүүгийн бус хувьсагчийн агуулсан байдаг. Ийм хувьсагчдад тодорхой бүс нутгийн газар хөдлөлтийн гарз хохирлын индекс, тодорхой нэг хотын агаарын хэмийн индекс хамаарна. Гэрээний аль нэг талд тусгайлан хамаарах санхүүгийн бус хувьсагчдад уг гэрээний талын хөрөнгийг сүйрүүлэх буюу хохирол учруулах гал түймрийн тохиолдол эсвэл үл тохиолдол хамаарна. Хэрэв бодит үнэ цэнэ нь санхүүгийн бус хөрөнгийн (санхүүгийн хувьсагчийн) зөвхөн зах зээлийн үнийн өөрчлөлт төдийгүй тухайн санхүүгийн бус хөрөнгийг эзэмших нөхцөл байдлыг (санхүүгийн бус хувьсагчийг) бас тусгадаг бол санхүүгийн бус хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт нь тэрхүү эзний хувьд тусгайлан хамаарах шинжтэй байна. Жишээлбэл; тодорхой нэг автомашины үлдэх үнэ цэнийн талаархи баталгаа нь тухайн автомашины биет нөхцөл байдлын өөрчлөлтийн эрсдлийг тэрхүү баталгаа гаргагчид хүлээлгэдэг бол уг үлдэх үнэ цэнийн өөрчлөлт нь автомашины эзний хувьд тусгайлан хамаарах шинжтэй байна.

#### *Ажил гүйлгээний зардал*

- МЗУ26. Ажил гүйлгээний зардал нь агент (үүн дотроо, борлуулалтын агент байдлаар ажиллаж буй ажилтнууд), зөвлөгч, брокер, дилерт төлсөн хураамж, шимтгэл, эрх бүхий байгууллагын болон хөрөнгийн биржээс ногдуулсан шимтгэл, гүйлгээний татвар, төлбөрөөс бүрддэг. Өрийн урамшуулал буюу хөнгөлөлт, санхүүжилтийн зардал, дотоод захиргаа удирдлагын буюу эзэмшилтийн зардал нь ажил гүйлгээний зардалд хамаарахгүй.

#### *Худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр*

- МЗУ27. Худалдаа арилжаа нь ерөнхийдөө байнга, идэвхитэй хийгдэх худалдан авалт ба борлуулалтыг илэрхийлдэг бөгөөд худалдан арилжих зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүрийг үнийн богино хугацааны хэлбэлзэл буюу дилерийн ашиг олох зорилгоор ихэвчлэн ашигладаг.
- МЗУ28. Худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй санхүүгийн өр төлбөрт дараах зүйлс хамаарна:

- (а) Хейжийн хэрэглүүр гэж тайлагнаагүй үүсмэл өр төлбөр;
- (б) Зээлээр авсан санхүүгийн хөрөнгөө үнэ буурна гэсэн хүлээлттэй байгаа тул борлуулсан ба тэрхүү хөрөнгийг буцаан өгөх үүрэг (өөрөөр хэлбэл, байгууллага нь зээлээр авсан ба өөрөө өмчилдөггүй санхүүгийн хөрөнгөө борлуулсан);
- (в) Ойрын хугацаанд буцаан худалдаж авах зорилготойгоор гаргасан санхүүгийн өр төлбөр (жишээлбэл; гаргагч нь түүний бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс хамааран ойрын хугацаанд буцаан худалдан авч болох идэвхитэй арилжаалагддаг өрийн хэрэглүүр); ба
- (г) Хамтад нь удирдан зохицуулдаг, тодорхойлсон санхүүгийн хэрэглүүрүүдийн багцын нэг хэсэг бөгөөд богино хугацааны ашиг олж байсан сүүлийн үеийн тохиолдлын талаархи нотолгоо бүхий санхүүгийн өр төлбөр.

Худалдаа арилжааны үйл ажиллагааг санхүүжүүлэхийн тулд уг өр төлбөрийг ашигладаг байдал нь тэрхүү өр төлбөрийг худалдаа арилжааны зорилгоор эзэмшдэг гэдгийг дангаараа илэрхийлэхгүй.

*Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт*

МЗУ29. Дараах тохиолдолд байгууллага нь тогтмол дуусгавар болох хугацаатай санхүүгийн хөрөнгөнд оруулсан хөрөнгө оруулалтыг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших эерэг санаа төлөвлөгөөгүй байдаг:

- (а) Байгууллага нь санхүүгийн хөрөнгийг тодорхой бус хугацаанд эзэмших санаа зорилготой байх;
- (б) Байгууллага нь зах зээлийн хүүний түвшин буюу эрсдлийн өөрчлөлт, төлбөрийн чадварын хэрэгцээ шаардлага, хувилбар хөрөнгө оруулалтуудын бэлэн боломжит байдал ба өгөөжийн өөрчлөлт, санхүүжилтийн эх үүсвэрийн өөрчлөлт, гадаад валютын эрсдлийн нөхцөл буюу өөрчлөлтийн (дахин үл давтагдах ба уг байгууллага ул үндэслэлтэйгээр урьдчилан таамаглаж чадахгүй нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд) хариу болгон санхүүгийн хөрөнгөө борлуулахад бэлэн байх; эсвэл
- (в) Гаргагч нь санхүүгийн хөрөнгийг түүний хорогдуулсан өртгөөс мэдэгдэхүйц бага дүнгээр барагдуулах эрхтэй байх.

МЗУ30. Хувьсах хүүний түвшин бүхий өрийн хэрэглүүр нь дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын шалгуурыг хангах юм. Өмчийн хэрэглүүр нь тодорхой бус хугацаатай (энгийн хувьцаа гэх мэт) учраас эсвэл түүний эзэмшигчийн авч болох дүнг урьдчилан тодорхойлдоггүй (хувьцааны опцион, баталгаа ба адилтгах эрх гэх мэт) тул дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт болж чаддаггүй. Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын тодорхойлолтын хувьд, тогтмол буюу тодорхойлж болох төлбөр ба тогтоосон дуусгавар болох хугацаа гэдэг нь хүүний болон үндсэн төлбөр гэх мэт тухайн эзэмшигчид төлөх төлбөрүүдийн дүн, хугацааг

тодорхойлсон гэрээний нөхцлийг илэрхийлдэг. Санхүүгийн хөрөнгийн гэрээт төлбөрүүд нь тогтмол буюу тодорхойлж болох дүнтэй бөгөөд түүний ийм ангиллын бусад шалгуур хангагдаж байх тохиолдолд төлбөрийг төлөхгүй байх мэдэгдэхүйц эрсдэл нь уг санхүүгийн хөрөнгийг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших гэж ангилахад саад учруулахгүй. Хугацаагүй өрийн хэрэглүүр нь хүүг тодорхой бус хугацаанд төлөх нөхцөлтэй бол дуусгавар болох хугацаа байхгүй учраас тэрхүү хэрэглүүрийг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмшиж буй гэж ангилж болохгүй.

- МЗУ31. Эзэмшигч нь тухайн хэрэглүүрийг дуудах хүртэл эсвэл дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших санаа төлөвлөгөөтэй ба ийм чадвар боломжтой бөгөөд түүний бараг бүх дансны үнийг нөхөхөөр бол гаргагч нь дуудаж болох санхүүгийн хөрөнгийн хувьд дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт гэсэн ангиллын шалгуур хангагдана. Хэрэв хэрэгжүүлвэл тухайн гаргагчийн дуудах опцион нь уг хөрөнгийн дуусгавар болох хугацааг шууд хурдасгадаг. Гэвч эзэмшигч нь санхүүгийн хөрөнгийн бараг бүх дансны үнийг нөхөж чадахгүй байх нөхцлөөр түүнийг дуудах бол уг санхүүгийн хөрөнгийг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших гэж ангилж болохгүй. Дансны үнэ бараг нөхөгдөх эсэхийг тодорхойлохдоо байгууллага нь төлсөн аливаа урамшуулал ба капиталжуулсан ажил гүйлгээний зардлыг харгалзан үзнэ.
- МЗУ32. Санхүүгийн хөрөнгийн буцаах шинжийн төлөө төлбөр төлөх нь уг санхүүгийн хөрөнгийг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших санаа төлөвлөгөөний илэрхийлэлтэй зөрчилдөх тул буцаах эрхтэй санхүүгийн хөрөнгийг (өөрөөр хэлбэл, эзэмшигч нь тухайн санхүүгийн хөрөнгийг дуусгавар болох хугацаанаас өмнө буцаан төлөх буюу эргэлтээс гаргахыг тэрхүү гаргагчаас шаардах эрхтэй) дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт гэж ангилж болохгүй.
- МЗУ33. Ихэнх санхүүгийн хөрөнгийн хувьд бодит үнэ цэнэ нь хорогдуулсан өртгөөс илүү тохиромжтой хэмжүүр байдаг. Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших гэсэн ангилал нь тухайн байгууллага уг хөрөнгө оруулалтыг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших эерэг санаа төлөвлөгөөтэй ба ийм чадвар боломжтой байх зөвхөн тийм тохиолдолд хамаарах гажих нөхцөл юм. Байгууллагын үйл ажиллагаа нь ийм хөрөнгө оруулалтыг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших түүний санаа зорилго болон чадвар боломжинд эргэлзээ үүсгэх тохиолдолд зохих тодорхой хугацаанд энэхүү гажих нөхцлийг ашиглахыг 10-р параграфтаар хориглосон байдаг.
- МЗУ34. Банкны харилцах, хадгаламжаас мөнгийг бөөнөөр татах<sup>8</sup> эсвэл даатгагчид нөлөөлөх үүнтэй адилтгах нөхцөл гэх мэт “дарамт шахалттай” нөхцөл байдал нь тухайн байгууллага уг хөрөнгө оруулалтыг дуусгавар

<sup>8</sup> Bank run буюу a run on the bank's deposit-Банкны харилцах, хадгаламжаас аж ахуйн нэгж, байгууллага болон хувь хүмүүс мөнгөө бөөнөөр нэгэн зэрэг татаж авахын хэлдэг. Ред.Ч.Д.

болох хугацаа хүртэл эзэмших эерэг санаа зорилго ба чадвар боломжтой эсэхээ шийдвэрлэхдээ харгалзан үнэлэх хүчин зүйлс биш юм.

МЗУ35. Дараах зүйлсийн аль нэгэнд хамааралтай бол дуусгавар болох хугацаанаас өмнөх борлуулалт нь 10-р параграфт заасан нөхцлийг хангах бөгөөд ингэснээр бусад хөрөнгө оруулалтыг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших уг байгууллагын санаа төлөвлөгөөний талаар эргэлзээ үүсгэхгүй:

- (а) Гаргагчийн зээлийн үнэлэмжийн мэдэгдэхүйц доройтолт. Жишээлбэл; зээлийн үнэлэмжийн бууралт нь анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн зээлийн зэрэглэлийг лавлагаа болгосноор шүүн үнэлсэн тухайн гаргагчийн зээлийн үнэлэмжийн мэдэгдэхүйц бууралтын талаархи нотолгоогоор хангадаг бол зэрэглэл тогтоох гадны агентлагийн хийсэн зээлийн үнэлэмжийн бууралтын дараах борлуулалт нь бусад хөрөнгө оруулалтыг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших уг байгууллагын санаа төлөвлөгөөний талаар заавал эргэлзээ үүсгэх албагүй юм. Үүнтэй адилаар, дотоод зэрэглэл болон тэдгээр зэрэглэлийн өөрчлөлтийг тогтоох уг байгууллагын хандлага нь гаргагчийн зээлийн чанарын хувьд тууштай, найдвартай, бодитой хэмжилтийг бий болгодог тохиолдолд тухайн байгууллага нь эрсдлийг үнэлэхдээ дотоод зэрэглэлийг ашигладаг бол тэрхүү дотоод зэрэглэлийн өөрчлөлт нь зээлийн үнэлэмжийн мэдэгдэхүйц бууралт байгаа эсэхийг тогтооход гаргагчид тусалж болох юм. Хэрэв санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан гэсэн нотолгоо байгаа бол (67 ба 68-р параграфыг үзнэ үү) зээлийн үнэлэмжийн доройтлыг ихэвчлэн мэдэгдэхүйц гэж үздэг.
- (б) Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын хүүг татвараас чөлөөлөх нөхцлийг арилгах буюу мэдэгдэхүйц бууруулах татварын хуулийн өөрчлөлт (гэхдээ хүүний орлогод хамаарах татварын хязгаарын түвшинг хянан засварлах татварын хуулийн өөрчлөлт биш).
- (в) Байгууллагын одоогийн хүүний түвшний эрсдлийн төлөв байдал буюу зээлийн эрсдлийн бодлогыг хадгалахын тулд дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтыг борлуулах эсвэл шилжүүлэхэд хүргэх улсын секторын томоохон нэгдэл эсвэл (сегментийн борлуулалт гэх мэт) томоохон данснаас хасалт (хэдийгээр улсын секторын нэгдэл нь тухайн байгууллагын хяналтанд буй үйл явдал боловч хүүний түвшний эрсдлийн төлөв байдал буюу зээлийн эрсдлийн бодлогыг хадгалахын тулд түүний хөрөнгө оруулалтын багцад оруулах өөрчлөлт нь урьдчилан таамагласан гэхээсээ үр дагаврын шинжтэй байж болно).
- (г) Зөвшөөрөгдөх хөрөнгө оруулалтыг бүрдүүлдэг зүйлс эсвэл тодорхой төрлийн хөрөнгө оруулалтын хамгийн их түвшинг мэдэгдэхүйц өөрчилдөг, ингэснээр дуусгавар болох хугацаа хүртэл



эзэмших хөрөнгө оруулалтаа тухайн байгууллага данснаас хасахад хүргэдэг хуулийн болон зохицуулалтын шаардлагуудын өөрчлөлт.

- (д) Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтаа борлуулж, хэмжээг нь бууруулахад уг байгууллагыг хүргэдэг тухайн салбарын капиталын хүрэлцээтэй байдлын талаархи шаардлагуудын мэдэгдэхүйц нэмэгдэлт.
  - (е) Эрсдэлд суурилсан капиталын хүрэлцээтэй байдлын зорилгоор ашигладаг уг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтуудын эрсдлийн жингийн мэдэгдэхүйц нэмэгдэлт.
- МЗУ36. Дараах тохиолдолд байгууллага нь тогтмол хугацаатай санхүүгийн хөрөнгөнд оруулсан хөрөнгө оруулалтыг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших батлан илэрхийлсэн чадвар, боломжгүй байдаг:
- (а) Байгууллага нь дуусгавар болох хугацаа хүртэл уг хөрөнгө оруулалтыг үргэлжлүүлэн санхүүжүүлэх санхүүгийн нөөцгүй байх; эсвэл
  - (б) Санхүүгийн хөрөнгийг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших түүний санаа төлөвлөгөөнд саад учруулж болох одоогийн хуулийн буюу бусад саад хязгаарлалтанд уг байгууллага хамаардаг байх. (Гэхдээ гаргагчийн дуудах опцион нь санхүүгийн хөрөнгийг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших уг байгууллагын санаа төлөвлөгөөнд заавал саад учруулах албагүй юм. МЗУ31-р параграфыг үзнэ үү.)
- МЗУ37. МЗУ29-МЗУ36-р параграфт зааснаас бусад нөхцөл байдал нь байгууллага тухайн хөрөнгө оруулалтыг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших эерэг санаа төлөвлөгөөгүй буюу чадвар боломжгүй гэдгийг илэрхийлнэ.
- МЗУ38. Байгууллага нь дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтаа уг дуусгавар болох өдөр хүртэл эзэмших өөрийн санаа зорилго ба чадвар боломжоо тэдгээр санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үед, түүнчлэн дараагийн тайлант үе бүрийн эцэст үнэлж үзнэ.

#### *Зээл ба авлага*

- МЗУ39. Тогтмол буюу тодорхойлж болох төлбөр бүхий аливаа үүсмэл бус санхүүгийн хөрөнгө (үүн дотроо, зээлийн хөрөнгө, авлага, өрийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт, банкин дахь харилцах, хадгаламж) нь зээл ба авлагын тодорхойлолтыг хангах боломжтой юм. Гэвч идэвхитэй зах зээл дэх жишиг үнэ бүхий санхүүгийн хөрөнгө (жишиг үнэ бүхий өмчийн хэрэглүүр гэх мэт, МЗУ103-р параграфыг үзнэ үү) нь зээл эсвэл авлага гэж ангилах шалгуурыг хангахгүй. Зээл ба авлагын тодорхойлолтыг хангахгүй санхүүгийн хөрөнгө нь дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт гэж ангилах нөхцлийг хангаж байвал (10-р параграф болон МЗУ29-МЗУ38-р параграфыг үзнэ үү) тэдгээрийг ингэж ангилж болно. Зээл эсвэл авлага гэж ангилахгүй

санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үедээ байгууллага нь түүнийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн эсвэл борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө гэж ангилж болно.

### **Дагалдах үүсмэл хэрэглүүр (11-13-р параграф)**

- МЗУ40. Үндсэн гэрээ нь тогтоосон буюу урьдчилан тодорхойлсон дуусгавар болох хугацаагүй бөгөөд байгууллагын цэвэр хөрөнгөнд үлдэх хувь оролцоог илэрхийлдэг бол энэ нь өмчийн хэрэглүүрийн эдийн засгийн шинж чанар ба эрсдэлтэй байх бөгөөд дагалдах үүсмэл хэрэглүүр нь тэрхүү үндсэн гэрээтэйгээ нягт уялдаатай байхын тулд тухайн байгууллагад хамаарах цэвэр хөрөнгө/өмчийн шинж чанаруудыг агуулсан байх шаардлагатай. Хэрэв үндсэн гэрээ нь өмчийн хэрэглүүр биш бөгөөд санхүүгийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангадаг бол энэ нь өрийн хэрэглүүрийн эдийн засгийн шинж чанар ба эрсдэлтэй байна.
- МЗУ41. Опцион бус дагалдах үүсмэл хэрэглүүрийг (дагалдах форвард буюу своп гэх мэт) анх хүлээн зөвшөөрөх үед тэг (0) бодит үнэ цэнэтэй байлгахын тулд түүний тусгайлан заасан буюу шууд бусаар илэрхийлэх нөхцлүүдэд үндэслэн үндсэн гэрээнээс салган тусгаарладаг. Опционд суурилсан дагалдах үүсмэл хэрэглүүрийг (дагалдах буцаах опцион, дуудах опцион, хүүний түвшний дээд хэмжээ эсвэл доод хэмжээ, своп гэх мэт) тухайн опционы шинжийн тусгайлан заасан нөхцлүүдэд үндэслэн үндсэн гэрээнээс салган тусгаарладаг. Үндсэн гэрээний анхны дансны үнэ нь уг дагалдах үүсмэл хэрэглүүрийг салгасны дараах үлдсэн дүн байна.
- МЗУ42. Нэг холимог гэрээн дэх дагалдах олон үүсмэл хэрэглүүрүүдийг ерөнхийдөө нэг нийлмэл дагалдах хэрэглүүр гэж үздэг. Гэхдээ өмчийн хэрэглүүр гэж ангилдаг дагалдах үүсмэл хэрэглүүрийг (УСНББОУС 28-ыг үзнэ үү) хөрөнгө эсвэл өр төлбөр гэж ангилсан үүсмэл хэрэглүүрүүдээс тусад нь тайлагнана. Түүнчлэн, уг хэрэглүүр нь нэгээс олон дагалдах үүсмэл хэрэглүүртэй бөгөөд тэдгээр үүсмэл хэрэглүүрүүд нь өөр өөр эрсдэлтэй холбоотой, мөн шууд салган тусгаарлаж болох ба бие биенээсээ хараат бус бол тэдгээрийг тус тусад нь тайлагнана.
- МЗУ43. Дараах жишээн дэх дагалдах үүсмэл хэрэглүүрийн эдийн засгийн шинж чанар ба эрсдэл нь үндсэн гэрээтэй нягт холбоогүй байна (12(а) параграф). Эдгээр жишээнд 12(б), (в) параграфт заасан нөхцөл хангагдана гэж үзээд байгууллага нь уг дагалдах үүсмэл хэрэглүүрийг үндсэн гэрээнээс тусдаа тайлагнана:
- (а) Өмч эсвэл бараа бүтээгдэхүүний үнийн буюу индексийн өөрчлөлтөнд үндэслэн хувьсан өөрчлөгдөх дүн бүхий мөнгөөр эсвэл бусад хөрөнгөөр тухайн хэрэглүүрийг буцаан худалдан авахыг гаргагчаас шаардах боломжийг эзэмшигчдээ олгодог, уг хэрэглүүрийг дагалдсан буцаах опцион нь энэхүү өрийн үндсэн хэрэглүүртэй нягт уялдаатай байдаггүй.
  - (б) Өмчийн хэрэглүүрийг тодорхой үнээр буцаан худалдан авах боломжийг тухайн гаргагчид олгодог уг өмчийн хэрэглүүрийг

дагалдсан дуудах опцион нь эзэмшигчийн зүгээс авч үзвэл тэрхүү үндсэн өмчийн хэрэглүүртэй нягт уялдаатай байдаггүй (гаргагчийн зүгээс авч үзвэл уг дуудах опцион нь УСНББОУС 28-ын дагуу ингэж ангилах нөхцлийг хангаж байвал өмчийн хэрэглүүр болох бөгөөд ийм тохиолдолд энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй).

- (в) Өрийн хэрэглүүрийн дуусгавар болох хугацаа хүртэлх үлдсэн хугацааг сунгах опцион буюу шууд биелүүлэх нөхцөл нь уг сунгалтын хугацаанд хүүний түвшинг одоогийн зах зээлийн хүүний түвшинтэй ойролцоо болгон мөн нэгэн зэрэг тохируулга хийдэггүй л бол энэ нь тухайн өрийн хэрэглүүртэй нягт уялдаатай байдаггүй. Байгууллага нь өрийн хэрэглүүр гаргасан бөгөөд өрийн хэрэглүүрийг эзэмшигч нь уг өрийн хэрэглүүрт хамаарах дуудах опционыг гуравдагч этгээдэд гаргасан бол дуудах опционыг хэрэгжүүлсний үр дүнд тэрхүү өрийн хэрэглүүрийг дахин зах зээлд гаргахад оролцох буюу туслалцаа үзүүлэхийг анхны өрийн хэрэглүүр гаргагчаас шаардаж болох тохиолдолд анхны өрийн хэрэглүүр гаргагч нь тухайн дуудах опционыг өрийн хэрэглүүрийн дуусгавар болох өдөр хүртэлх хугацааны сунгалттай адилтгаж үзнэ.
- (г) Өрийн үндсэн хэрэглүүр эсвэл даатгалын гэрээг дагалдан гарсан, ингэснээр хүү буюу үндсэн дүн нь өмчийн хэрэглүүрийн үнэ цэнээр индексжсэн, өмчөөр индексжүүлсэн хүү буюу үндсэн дүнгийн төлбөр нь үндсэн хэрэглүүртэй нягт холбоотой байдаггүй. Яагаад гэвэл, үндсэн гэрээний болон дагалдах үүсмэл хэрэглүүрийн эрсдлүүд нь өөр хоорондоо ижил төсөөгүй байдаг.
- (д) Өрийн үндсэн хэрэглүүр эсвэл даатгалын гэрээг дагалдан гарсан, ингэснээр хүү буюу үндсэн дүн нь бараа бүтээгдэхүүний (газрын тос гэх мэт) үнээр индексжсэн, бараа бүтээгдэхүүнээр индексжүүлсэн хүү буюу үндсэн дүнгийн төлбөр нь үндсэн хэрэглүүртэй нягт холбоотой байдаггүй. Яагаад гэвэл, үндсэн гэрээний болон дагалдах үүсмэл хэрэглүүрийн эрсдлүүд нь өөр хоорондоо ижил төсөөгүй байдаг.
- (е) Хөрвөх өрийн хэрэглүүрийг дагалдан гарсан, өмчид хөрвүүлэх шинж нь уг хэрэглүүрийн эзэмшигчийн зүгээс авч үзвэл өрийн үндсэн хэрэглүүртэй нягт холбоотой байдаггүй (гаргагчийн зүгээс авч үзвэл, өмчид хөрвөх опцион нь УСНББОУС 28-ын дагуу ингэж ангилах нөхцлийг хангаж байвал өмчийн хэрэглүүр болох бөгөөд ийм тохиолдолд энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй).
- (ж) Өрийн үндсэн хэрэглүүр эсвэл даатгалын үндсэн гэрээг дагалдан гарсан, дуудах опцион, буцаах опцион, урьдчилсан төлбөрийн опцион нь хэрэгжүүлэх өдөр тус бүрээрх тухайн опционы хэрэгжүүлэх үнэ нь өрийн үндсэн хэрэглүүрийн хорогдуулсан өртөг эсвэл даатгалын үндсэн гэрээний дансны үнэтэй ойролцоогоор тэнцүү байхаас бусад тохиолдолд уг үндсэн гэрээтэй нягт холбоотой байдаггүй. Дагалдах дуудах эсвэл буцаах опционы шинж бүхий хөрвөх өрийн хэрэглүүрийн гаргагчийн зүгээс авч

үзвэл, уг дуудах буюу буцаах опцион тухайн өрийн үндсэн гэрээтэй нягт холбоотой эсэх үнэлгээг УСНББОУС 28-ын дагуу цэвэр хөрөнгө/өмчийн элементийг салган тусгаарлахын өмнө хийдэг.

- (и) Өрийн үндсэн хэрэглүүрийг дагалдан гарсан бөгөөд өөрөө өмчилдөггүй байж болох тухайн харгалзах хөрөнгийн зээлийн эрсдлийг нөгөө талдаа ('баталгаа гаргагч') шилжүүлэх боломжийг гэрээний нэг талд ('жинхэнэ эзэн') олгодог зээлийн үүсмэл хэрэглүүр нь өрийн үндсэн хэрэглүүртэй нягт холбоотой байдаггүй. Ийм зээлийн үүсмэл хэрэглүүр нь тухайн харгалзах хөрөнгийг шууд өмчлөхгүй боловч түүнтэй холбоотой зээлийн эрсдлийг хариуцах боломжийг уг баталгаа гаргагчид олгодог.

МЗУ44. Холимог гэрээний жишээ нь; өмч буюу бараа бүтээгдэхүүний индексийн өсөх эсвэл буурах өөрчлөлтөнд үндэслэн хувьсан өөрчлөгдөх дүн бүхий мөнгөөр эсвэл бусад санхүүгийн хөрөнгөөр солилцож, тухайн санхүүгийн хэрэглүүрийг түүний гаргагчид буцаан өгөх эрхийг эзэмшигчдээ олгодог санхүүгийн хэрэглүүр ('буцаах эрхтэй хэрэглүүр') юм. Анх хүлээн зөвшөөрөх үедээ гаргагч нь тухайн буцаах эрхтэй хэрэглүүрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн, санхүүгийн өр төлбөр гэж ангилдагаас бусад тохиолдолд үндсэн гэрээ нь МЗУ40-р параграфын дагуу өрийн хэрэглүүр болох ба индексжүүлсэн үндсэн төлбөр нь МЗУ43(а) параграфын дагуу уг өрийн үндсэн хэрэглүүртэй нягт холбоотой байдаггүй тул тэрхүү дагалдах үүсмэл хэрэглүүрийг (өөрөөр хэлбэл, индексжүүлсэн үндсэн төлбөрийг) 12-р параграфын дагуу салган тусгаарлах шаардлагатай байдаг. Үндсэн төлбөр нь өсөж эсвэл буурч болох учраас дагалдах үүсмэл хэрэглүүр нь суурь хувьсагчаар үнэ цэнийг нь индексжүүлсэн, опцион бус үүсмэл хэрэглүүр болно.

МЗУ45. Байгууллагын цэвэр хөрөнгийн үнэ цэнэтэй хувь тэнцүүлсэн хэсэгтэй (нээлттэй хамтын сангийн нэгжүүд эсвэл нэгжээр-холбогдсон зарим хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн гэх мэт) тэнцүү мөнгөөр дурын хугацаанд буцааж болох, тийм буцаах эрхтэй хэрэглүүр байх тохиолдолд дагалдах үүсмэл хэрэглүүрийг салган тусгаарлах ба бүрэлдэхүүн хэсэг нэг бүрийг тайлагнахын үр нөлөө нь хэрэв эзэмшигч уг санхүүгийн хэрэглүүрийг түүний гаргагчид буцаан өгөх эрхээ хэрэгжүүлсэн бол тухайн тайлант үеийн эцэст төлөх дүн буюу эргэлтээс гаргах дүнгээр тэрхүү холимог хэрэглүүрийг хэмжихэд хүргэнэ.

МЗУ46. Дараах жишээн дэх дагалдах үүсмэл хэрэглүүрийн эдийн засгийн шинж чанар ба эрсдэл нь үндсэн гэрээний эдийн засгийн шинж чанар ба эрсдэлтэй нягт холбоотой байна. Эдгээр жишээний хувьд байгууллага нь дагалдах үүсмэл хэрэглүүрийг тухайн үндсэн гэрээнээс тусад нь тайлагнахгүй.

- (а) Эзэмшигч нь өөрийн хүлээн зөвшөөрсөн бараг бүх хөрөнгө оруулалтыг нөхөхгүй байдлаар, эсвэл тухайн дагалдах үүсмэл хэрэглүүр нь үндсэн гэрээний дагуу эзэмшигчийн хүртэх анхны өгөөжийг хамгийн наад зах нь хоёр дахин нэмэгдүүлэх ба тэрхүү үндсэн гэрээтэй ижил төсөөтэй нөхцөл бүхий гэрээний хувьд зах

зээлээр олгох өгөөжөөс наад зах нь хоёр дахин их өгөөжийг өгөх байдлаар холимог гэрээг барагдуулахаас бусад тохиолдолд, хүүтэй өрийн үндсэн гэрээний эсвэл даатгалын гэрээний дагуу төлөх эсвэл хүлээн авах байсан хүүний дүнг өөрчилж чадах хүүний түвшин буюу хүүний түвшний индекс болох суурь хэрэглүүрийг дагалдан гарсан үүсмэл хэрэглүүр нь тухайн үндсэн гэрээтэйгээ нягт холбоотой байдаг.

- (б) Хүүний түвшний дээд эсвэл доод хэмжээний гэрээг гаргах үед дээд хэмжээ нь зах зээлийн хүүний түвшинтэй тэнцүү буюу түүнээс өндөр, харин доод хэмжээ нь зах зээлийн хүүний түвшинтэй тэнцүү буюу түүнээс бага бөгөөд тухайн үндсэн гэрээний хувьд хүүний түвшний дээд эсвэл доод хэмжээ нь хөшүүргийн нөлөөгүй бол өрийн гэрээ эсвэл даатгалын гэрээг дагалдан гарсан хүүний түвшний дээд буюу доод хэмжээ нь уг үндсэн гэрээтэйгээ нягт холбоотой байна. Үүнтэй адилаар, хөрөнгийн хувьд хүлээн авах эсвэл төлөх үнийн дээд болон доод хэмжээ нь анхнаасаа мөнгөн алдагдалтай байсан бөгөөд хөшүүргийн нөлөөгүй бол тэрхүү дээд болон доод хэмжээг тогтоосон, хөрөнгийг (жишээлбэл; бараа бүтээгдэхүүнийг) худалдан авах буюу борлуулах гэрээний заалт нь уг үндсэн гэрээтэйгээ нягт холбоотой байна.
- (в) Гадаад валютаар илэрхийлэгдсэн үндсэн дүнгийн буюу хүүний цуврал төлбөрүүдийг бүрдүүлдэг бөгөөд өрийн үндсэн хэрэглүүрийг дагалдан гардаг гадаад валютаар илэрхийлэгдсэн дагалдах үүсмэл хэрэглүүр (жишээлбэл; хоёр валютаар илэрхийлэгдсэн бонд) нь тухайн өрийн үндсэн хэрэглүүртэй нягт холбоотой байдаг. УСНББОУС 4 нь мөнгөн зүйлсээс үүссэн гадаад валютын олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөхийг шаарддаг тул ийм үүсмэл хэрэглүүрийг түүний үндсэн хэрэглүүрээс салган тусгаарлахгүй.
- (г) Санхүүгийн хэрэглүүр биш (гадаад валютаар үнийг нь илэрхийлдэг санхүүгийн бус зүйлийг худалдан авах буюу борлуулах гэрээ гэх мэт), эсвэл даатгалын гэрээ байх тийм үндсэн гэрээг дагалдан гардаг, гадаад валютаар илэрхийлэгдсэн дагалдах үүсмэл хэрэглүүр нь хөшүүргийн нөлөөгүй, опционы шинжийг агуулаагүй бөгөөд дараах валютуудын аль нэгээр илэрхийлэгдэх төлбөрүүдийг шаарддаг бол ийм дагалдах хэрэглүүр нь тухайн үндсэн гэрээтэйгээ нягт холбоотой байна:
  - (i) Тухайн гэрээний аль нэг үндсэн оролцогч талын бүртгэлийн валют;
  - (ii) Худалдан авах буюу нийлүүлэх уг холбогдох бараа, үйлчилгээний үнийг дэлхий дахинд хийгдэж буй худалдаа арилжаанд түгээмэл илэрхийлдэг валют (түүхий газрын тосны худалдаа арилжааны хувьд ам доллар гэх мэт); эсвэл
  - (iii) Тухайн ажил гүйлгээ хийгдэж буй эдийн засгийн орчинд санхүүгийн бус зүйлсийг худалдан авах буюу борлуулах

гэрээнүүдэд нийтлэг ашигладаг валют (жишээлбэл; орон нутгийн ажил гүйлгээ эсвэл гадаад худалдаанд нийтлэг ашигладаг харьцангуй тогтвортой, хөрвөх чадвар сайтай валют).

- (д) Үндсэн гэрээ нь (i) дагалдах үүсмэл хэрэглүүрийг өөртөө агуулаагүй санхүүгийн хэрэглүүрийн гэрээний мөнгөн гүйлгээг хүлээн авах эрхийг салган тусгаарласнаар анх үүссэн, ба (ii) өрийн анхны үндсэн гэрээнд тусгаагүй аливаа нөхцлийг агуулаагүй тохиолдолд зөвхөн хүүний эсвэл зөвхөн үндсэн дүнгийн СТРИП-ийг дагалдан гардаг урьдчилсан төлбөрийн дагалдах опцион нь үндсэн гэрээтэйгээ нягт холбоотой байна.
- (е) Хэрэв дагалдах үүсмэл хэрэглүүр нь (i) хэрэглээний үнийн индексээр тооцсон түрээсийн төлбөрийн индекс гэх мэт инфляцитай холбоотой индекс (түрээс нь хөшүүргийн нөлөөгүй бөгөөд тухайн индекс нь уг байгууллагын эдийн засгийн орчин дахь инфляцитай холбоотой), (ii) холбогдох борлуулалтанд үндэслэсэн түрээсийн хувьсах төлбөрүүд, эсвэл (iii) хувьсах хүүний түвшинд үндэслэсэн түрээсийн хувьсах төлбөрүүд бол түрээсийн үндсэн гэрээг дагалдан гардаг уг дагалдах үүсмэл хэрэглүүр нь үндсэн гэрээтэйгээ нягт холбоотой байна.
- (ж) Нэгжээр-илэрхийлсэн төлбөрүүдийг тухайн сангийн хөрөнгийн бодит үнэ цэнийг тусгах нэгжийн одоогийн үнэ цэнээр хэмждэг бол санхүүгийн үндсэн хэрэглүүр эсвэл даатгалын үндсэн гэрээг дагалдан гардаг, нэгжтэй холбогдох шинж нь тухайн үндсэн хэрэглүүр буюу үндсэн гэрээтэйгээ нягт холбоотой байна. Нэгжтэй холбогдох шинж гэдэг нь дотоод буюу гадаад хөрөнгө оруулалтын сангийн нэгжүүдээр илэрхийлэгдсэн төлбөрийг шаардах гэрээний нөхцөл юм.
- (и) Байгууллага нь (үндсэн гэрээг харгалзан үзэхгүйгээр) дагалдах үүсмэл хэрэглүүрийг тусад нь хэмжиж чадахааргүй тийм байдлаар тухайн дагалдах үүсмэл хэрэглүүр ба даатгалын үндсэн гэрээ нь харилцан бие биенээсээ хамааралтай бол даатгалын гэрээг дагалдан гардаг үүсмэл хэрэглүүр нь уг даатгалын үндсэн гэрээтэйгээ нягт холбоотой байна.

*Дагалдах үүсмэл хэрэглүүрүүдийг агуулсан хэрэглүүр*

МЗУ47. Байгууллага нь нэг буюу хэд хэдэн дагалдах үүсмэл хэрэглүүрийг агуулсан холимог (нэгдсэн) хэрэглүүрийн оролцогч нэг тал болсон тохиолдолд 12-р параграф нь ийм аливаа дагалдах үүсмэл хэрэглүүрийг тодорхойлох, түүнийг үндсэн гэрээнээс салган тусгаарлах шаардлагатай эсэхийг үнэлэх, түүнчлэн ингэж салгах шаардлагатай үүсмэл хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрөх болон дараагийн тайлант үед бодит үнэ цэнээр хэмжихийг тухайн байгууллагаас шаарддаг. Ийм шаардлага нь нилээд нарийн цогц буюу бүхэлдээ уг хэрэглүүрийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжихээс арай найдвартай бус хэмжилт хийхэд хүргэдэг. Ийм учраас энэ Стандарт нь холимог гэрээг бүхэлд нь

ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилахыг зөвшөөрдөг.

МЗУ48. 12-р параграф нь дагалдах үүсмэл хэрэглүүрийг түүний үндсэн гэрээнээс салган тусгаарлахыг шаарддаг эсвэл ингэж салгахыг хориглодог эсэхээс үл хамааран ийм ангиллыг ашиглаж болох юм. Гэвч холимог гэрээг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилах нь уг нарийн цогц байдлыг багасгахгүй эсвэл найдвартай байдлыг нэмэгдүүлэхгүй учраас 12(а) ба (б) параграфт заасан тохиолдлуудад 13-р параграф нь ингэж ангилах үндэслэл болохгүй.

### **Хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлт (16-44-р параграф)**

*Анхны хүлээн зөвшөөрөлт (16-р параграф)*

МЗУ49. 16-р параграфт заасан зарчмын үр дүнд байгууллага нь санхүүгийн хөрөнгийн шилжүүлэлтийг борлуулалт гэж тайлагнахыг хориглодог үүсмэл хэрэглүүрээс (МЗУ64-р параграфыг үзнэ үү) бусад, үүсмэл хэрэглүүрийн хувьд гэрээний бүх эрх ба үүргээ өөрийн санхүүгийн байдлын тайландаа хөрөнгө, өр төлбөр гэж тус тус хүлээн зөвшөөрнө. Хэрэв санхүүгийн хөрөнгийн шилжүүлэлт нь үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангахгүй бол шилжүүлэн авагч нь уг шилжүүлсэн хөрөнгийг өөрийнхөө хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхгүй (МЗУ65-р параграфыг үзнэ үү).

МЗУ50. 16-р параграфт заасан зарчмыг мөрдөх жишээг доор харуулав:

- (а) Байгууллага нь гэрээний нэг тал болсон, ингэснээр мөнгө хүлээн авах хууль ёсны эрхтэй эсвэл мөнгө төлөх хууль ёсны үүрэгтэй болсон тохиолдолд нөхцөлт бус авлага, өглөгийг хөрөнгө эсвэл өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.
- (б) Бараа, үйлчилгээг худалдан авах эсвэл борлуулах арилжааны баталгааны үр дүнд олж эзэмших хөрөнгө ба хариуцах өр төлбөрийг, хамгийн наад зах нь талуудын аль нэг нь тухайн гэрээний дагуу үүргээ гүйцэтгэх хүртэл ерөнхийдөө хүлээн зөвшөөрдөггүй. Жишээлбэл; үл цуцлагдах захиалга хүлээн авсан байгууллага нь уг баталгаат захиалгын өдөр ерөнхийдөө хөрөнгө хүлээн зөвшөөрөхгүй (мөн захиалга өгсөн байгууллага нь өр төлбөр хүлээн зөвшөөрөхгүй), харин тухайн захиалсан барааг ачуулж, хүргэх буюу үйлчилгээг үзүүлэх хүртэл хүлээн зөвшөөрөлтийг хойшлуулна. Хэрэв санхүүгийн бус зүйлсийг худалдан авах буюу борлуулах арилжааны баталгаа нь 4-6-р параграфын дагуу энэ Стандартын цар хүрээнд хамаарах бол түүний цэвэр бодит үнэ цэнийг уг баталгааны өдрөөр хөрөнгө эсвэл өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө (доорх (в) заалтыг үзнэ үү). Түүнчлэн, өмнө нь хүлээн зөвшөөрөөгүй байсан арилжааны баталгааг бодит үнэ цэнийн хейжид хейжийн зүйл гэж сонгосон бол уг хейж хийсэн эрсдэлд хамаарах цэвэр бодит үнэ цэнийн аливаа өөрчлөлтийг тухайн

хейжийн эхлэлээс хойш хөрөнгө эсвэл өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө (104 ба 105-р параграфыг үзнэ үү).


- (в) Энэ Стандартын цар хүрээнд хамаарах (2-6-р параграфыг үзнэ үү) форвард гэрээг түүний барагдуулалт хийгдсэн өдөр биш, харин баталгаат өдөр хөрөнгө эсвэл өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө. Байгууллага нь форвард гэрээний нэг тал болсон тохиолдолд эрх ба үүргийн бодит үнэ цэнэ нь ямагт тэнцүү, ингэснээр форвард гэрээний цэвэр бодит үнэ цэнэ нь тэг байдаг. Хэрэв эрх ба үүргийн цэвэр бодит үнэ цэнэ нь тэг биш бол уг гэрээг хөрөнгө эсвэл өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.
- (г) Эзэмшигч эсвэл гаргагч нь тухайн опционы гэрээний аль нэг тал болсон тохиолдолд энэ Стандартын цар хүрээнд хамаарах (2-6-р параграфыг үзнэ үү) опционы гэрээг хөрөнгө эсвэл өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.
- (д) Байгууллага нь гэрээний аль нэг тал болохгүй тул төлөвлөсөн ирээдүйн ажил гүйлгээ нь хэрэгжих хэр өндөр магадлалтай гэдгээс үл хамааран хөрөнгө эсвэл өр төлбөр биш юм.

*Санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлт (17-39-р параграф)*

МЗУ51. Санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх эсэх, ямар хэмжээгээр үл хүлээн зөвшөөрөх талаархи үнэлгээг дараах блок схемд үлгэрчлэн харуулав.



САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ



**Байгууллага нь санхүүгийн хөрөнгөөс үүсэх мөнгөн гүйлгээг хүлээн авах гэрээний эрхийг хадгалан үлдэх боловч нэг буюу хэд хэдэн хүлээн авагч талуудад уг мөнгөн гүйлгээг төлөх гэрээний үүргийг хүлээдэг хэлцэл (20(б) параграф)**

- МЗУ52. Тухайлбал; байгууллага нь итгэлцлийн сан бөгөөд өөрийн эзэмшдэг уг суурь санхүүгийн хөрөнгө дэх жинхэнэ хувь оролцоог<sup>9</sup> хөрөнгө оруулагчдад санал болгон гаргах ба өөрөө тэдгээр санхүүгийн хөрөнгөнд үйлчилгээ үзүүлдэг тохиолдолд 20(б) параграфт дурдсан нөхцөл байдал үүснэ (байгууллага нь санхүүгийн хөрөнгөөс үүсэх мөнгөн гүйлгээг хүлээн авах гэрээний эрхийг хадгалан үлдэх боловч нэг буюу хэд хэдэн хүлээн авагч талуудад уг мөнгөн гүйлгээг төлөх гэрээний үүргийг хүлээнэ). Энэ тохиолдолд хэрэв 21 ба 22-р параграфт заасан нөхцөл биелвэл уг санхүүгийн хөрөнгө нь үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангах юм.
- МЗУ53. 21-р параграфыг мөрдөх үед байгууллага нь жишээлбэл; санхүүгийн хөрөнгийг үүсгэн бий болгогч эсвэл уг санхүүгийн хөрөнгийг олж эзэмшсэн бөгөөд түүний мөнгөн гүйлгээг харилцан хамааралгүй гуравдагч тал болох хөрөнгө оруулагчдад дамжуулан өгдөг хяналтанд буй байгууллагыг өөртөө агуулсан эдийн засгийн нэгдмэл байгууллага байж болно.

**Өмчлөлтэй холбоотой эрсдэл ба өгөөжийн шилжүүлэлтийн үнэлгээ (22-р параграф)**

- МЗУ54. Байгууллага нь өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн жишээ:
- (а) санхүүгийн хөрөнгийн нөхцөлт бус борлуулалт;
  - (б) санхүүгийн хөрөнгийг буцаан авах тэр үеийн бодит үнэ цэнээр түүнийг буцаан худалдан авах опционы хамтаар уг санхүүгийн хөрөнгийг борлуулах; ба
  - (в) санхүүгийн хөрөнгийг их мөнгөн алдагдалтай буцаах опцион эсвэл дуудах опционы<sup>10</sup> хамтаар борлуулах (өөрөө хэлбэл, одоогоор

<sup>9</sup> Beneficial interest-Жинхэнэ хувь оролцоо. **Beneficial owner (жинхэнэ эзэн)** гэдэг нь хөрөнгийн хуулийн эрх өөр нэг этгээдэд хамаарч байх үед өмч дэх тодорхой хөрөнгийн эрх (“захиран зарцуулах болон өмчлөлийн эрхийн бичиг”) тухайн этгээдэд хамаарах тохиолдолд хэрэглэдэг хуулийн нэр томъёо юм. Жишээлбэл; хамтын сангийн хувьцааг итгэмжлэлийн банкаар эсвэл үнэт цаасыг брокероор дамжуулан эзэмшдэг боловч хөрөнгийн бодит өмчлөгч нь “**жинхэнэ эзэн**” байна. Хэдий тийм боловч хадгалан хамгаалах болон тохиромжтой байдлын үүднээс банк эсвэл брокер нь өмчлөлийн эрхийг эзэмшиж болох бөгөөд тэд **нэрлэсэн буюу хуулийн эзэмшигч** юм. Харин хөрөнгийн өмчлөгч нь **жинхэнэ эзэн** болно.

<sup>10</sup> Out of the money put or call option-Мөнгөн алдагдалтай буцаах опцион эсвэл дуудах опцион. Дуудах опционы хувьд түүнийг хэрэгжүүлэх үнэ (өөрөөр хэлбэл ийм опционыг ашигласнаар үнэт цаасыг худалдан авах үнэ) нь суурь хөрөнгийн (үнэт цаасны) зах зээлийн үнээс их бол мөнгөн алдагдалтай гэнэ. Харин буцаах опционы хувьд түүнийг хэрэгжүүлэх үнэ (өөрөөр хэлбэл ийм опционыг ашигласнаар үнэт цаасыг худалдах үнэ) нь суурь хөрөнгийн зах зээлийн үнээс бага бол мөнгөн алдагдалтай гэнэ. Жишээлбэл;

мөнгөн алдагдалтай байгаа опцион нь түүний хугацаа дуусахаас өмнө мөнгөн ашигтай болох магадлал маш бага байх).

МЗУ55. Байгууллага нь өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалан үлдсэн жишээ:

- (а) Буцаан худалдан авах үнэ нь тогтмол дүн, эсвэл борлуулалтын үнэ дээр зээлдүүлэгчийн өгөөжийг нэмсэн дүн байх тийм тохиолдол дахь борлуулах ба буцаан худалдан авах ажил гүйлгээ;
- (б) Үнэт цаасыг зээлдүүлэх хэлцэл;
- (в) Зах зээлийн эрсдлийг тухайн байгууллагад буцаан шилжүүлдэг тийм нийт өгөөжийн свопын хамтаар санхүүгийн хөрөнгийг борлуулах;
- (г) Санхүүгийн хөрөнгийг их мөнгөн ашигтай буцаах опцион эсвэл дуудах опционы<sup>11</sup> хамтаар борлуулах (өөрөөр хэлбэл, одоогоор мөнгөн ашигтай байгаа опцион нь түүний хугацаа дуусахаас өмнө мөнгөн алдагдалтай болох магадлал маш бага байх); ба
- (д) Байгууллага нь тохиолдох магадлалтай зээлийн алдагдлын хувьд тухайн шилжүүлэн авагчид нөхөн төлбөр олгох баталгаа гаргаснаар уг богино хугацаат авлагыг борлуулах.

МЗУ56. Шилжүүлэлтийн үр дүнд байгууллага нь уг шилжүүлсэн хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн гэж үзсэн бол тухайн байгууллага нь тэрхүү шилжүүлсэн хөрөнгийг өөр шинэ ажил гүйлгээгээр буцаан олж эзэмшихээс бусад тохиолдолд шилжүүлсэн хөрөнгийг ирээдүйн тайлант үеүдэд хүлээн зөвшөөрөхгүй.

---

нэгж хувьцааг 12 ам доллараар худалдан авах дуудах опционы нэгжийг 3 ам доллараар буюу нийт 100 ширхэг опцион худалдан авсан гэж үзье. Хувьцааны зах зээлийн үнэ 10 ам доллар байх үед дуудах опционыг хэрэгжүүлвэл 1,200 /12x100/ ам доллараар 100 ширхэг хувьцаа худалдаж авах ба зах зээлийн үнээр буцааж борлуулвал 1,000 /10x100/ ам доллар болох бөгөөд зөрүү 200 ам доллар нь мөнгөн алдагдал болно. Гэхдээ ийм опционоос хүлээх бодит алдагдал нь 500 /1,000-1,200-300/ ам доллар байна. Ред.Ч.Д.

<sup>11</sup> In the money put or call option-Мөнгөн ашигтай буцаах опцион эсвэл дуудах опцион. Дуудах опционы хувьд түүнийг хэрэгжүүлэх үнэ (өөрөөр хэлбэл ийм опционыг ашигласнаар үнэт цаасыг худалдан авах үнэ) нь суурь хөрөнгийн (үнэт цаасны) зах зээлийн үнээс бага бол мөнгөн ашигтай гэнэ. Харин буцаах опционы хувьд түүнийг хэрэгжүүлэх үнэ (өөрөөр хэлбэл ийм опционыг ашигласнаар үнэт цаасыг худалдах үнэ) нь суурь хөрөнгийн зах зээлийн үнээс их бол мөнгөн ашигтай гэнэ. Жишээлбэл; нэгж хувьцааг 12 ам доллараар худалдан авах дуудах опционы нэгжийг 3 ам доллараар буюу нийт 100 ширхэг опцион худалдан авсан гэж үзье. Хувьцааны зах зээлийн үнэ 16 ам доллар байх үед дуудах опционыг хэрэгжүүлж, 1,200 /12x100/ ам доллараар 100 ширхэг хувьцаа худалдаж аваад буцаагаад зах зээлийн үнээр буюу 1,600 ам доллараар борлуулж болно. Энэ тохиолдолд мөнгөн ашиг нь 400 /1,600-1,200/ ам доллар байна. Харин бодит ашиг нь 100 /1,600-1,200-300/ ам доллар байна. Зах зээлийн үнэ 14.5 ам доллар байх үед опционыг хэрэгжүүлвэл хэдийгээр 50 /1,450-1,200-300/ ам долларын бодит алдагдалтай боловч мөнгөн ашиг нь 250 /1,450-1,200/ ам доллар байна. Ред.Ч.Д.

### Хяналтын шилжүүлэлтийн үнэлгээ

- МЗУ57. Хэрэв шилжүүлэн авагч нь уг шилжүүлсэн хөрөнгийг борлуулах практик боломжтой бол байгууллага нь тухайн шилжүүлсэн хөрөнгийн хувьд хяналтыг хадгалж үлдэхгүй. Харин шилжүүлэн авагч нь уг шилжүүлсэн хөрөнгийг борлуулах практик боломжгүй бол байгууллага нь тухайн шилжүүлсэн хөрөнгийн хувьд хяналтыг хадгалж үлдэнэ. Хэрэв шилжүүлсэн хөрөнгийг идэвхитэй зах зээлд арилждаг бол шилжүүлэн авагч нь тухайн хөрөнгийг тэрхүү байгууллагад буцаан өгөх шаардлагатай болсон үед түүнийг зах зээлээс буцаан худалдан авч чадах учраас уг шилжүүлэн авагч нь тухайн шилжүүлсэн хөрөнгийг борлуулах практик боломжтой байна. Жишээлбэл; шилжүүлсэн хөрөнгө нь түүнийг буцаан худалдан авах боломжийг байгууллагад олгодог опционд хамаардаг боловч тухайн шилжүүлэн авагч нь опционыг хэрэгжүүлсэн үед уг шилжүүлсэн хөрөнгийг зах зээлээс шууд олж авах боломжтой бол шилжүүлэн авагч нь тэрхүү шилжүүлсэн хөрөнгийг борлуулах практик боломжтой байж болох юм. Харин байгууллага нь ийм опционыг өөртөө хадгалж үлдсэн бөгөөд түүнийг хэрэгжүүлэх үед уг шилжүүлэн авагч нь тухайн хөрөнгийг зах зээлээс шууд олж авч чадахгүй бол шилжүүлэн авагч нь тэрхүү шилжүүлсэн хөрөнгийг борлуулах практик боломжгүй байна.
- МЗУ58. Шилжүүлэн авагч нь уг шилжүүлсэн хөрөнгийг харилцан хамааралгүй гуравдагч этгээдэд бүхэлд нь борлуулах боломжтой бөгөөд тэрхүү боломжоо өөрийн нэг талын санаачлагаар болон тухайн шилжүүлэлтийн хувьд нэмэлт хязгаарлалт тавихгүйгээр хэрэгжүүлэх чадвартай зөвхөн тийм тохиолдолд шилжүүлэн авагч нь уг шилжүүлсэн хөрөнгийг борлуулах практик боломжтой байна. Шилжүүлэн авагч нь уг шилжүүлсэн хөрөнгийн хувьд юу хийж болох талаархи гэрээний эрх эсвэл гэрээний ямар хязгаарлалт байгаа эсэх биш, харин тухайн шилжүүлэн авагч нь практикт юу хийх боломжтой гэдэг нь гол асуудал юм. Тухайлбал:
- (а) Шилжүүлсэн хөрөнгийн хувьд зах зээл байхгүй бол уг шилжүүлсэн хөрөнгийг данснаас хасах талаархи гэрээний эрх нь практик үр нөлөө багатай байна;
  - (б) Шилжүүлсэн хөрөнгийг данснаас хасах боломжийг хэрэв чөлөөтэй хэрэгжүүлж чадахгүй бол практик үр нөлөө багатай байна. Ийм учраас:
    - (i) Шилжүүлсэн хөрөнгийг данснаас хасах уг шилжүүлэн авагчийн боломж нь бусдын үйл ажиллагаанаас хараат бус байх ёстой (өөрөөр хэлбэл, үүнийг нэг талын санаачлагаар хэрэгжүүлэх боломжтой байх ёстой); ба
    - (ii) Шилжүүлэн авагч нь тухайн шилжүүлэлтийн хувьд хязгаарлах нөхцөл тавих буюу 'албадан хүчлэх' шаардлагагүйгээр (жишээ нь; зээлийн хөрөнгөнд хэрхэн үйлчилгээ үзүүлэх талаархи нөхцөл эсвэл уг хөрөнгийг буцаан худалдан авах эрхийг тухайн шилжүүлэн авагчид олгох опцион) уг

шилжүүлсэн хөрөнгийг данснаас хасах боломжтой байх ёстой.

МЗУ59. Уг шилжүүлсэн хөрөнгийг тухайн шилжүүлэн авагч борлуулах магадлалгүй байх нь шилжүүлэгч тэрхүү шилжүүлсэн хөрөнгийн хяналтыг хадгалж үлдсэн гэсэн утгыг дангаараа илэрхийлэхгүй юм. Харин буцаах опцион эсвэл баталгаа нь уг шилжүүлсэн хөрөнгийг тухайн шилжүүлэн авагч борлуулахад саад учруулж байвал шилжүүлэн авагч нь тэрхүү шилжүүлсэн хөрөнгийн хяналтыг хадгалж үлдсэн гэсэн үг юм. Жишээлбэл; буцаах опцион эсвэл баталгаа нь мэдэгдэхүйц үнэ цэнэтэй бол шилжүүлэн авагч нь үүнтэй ижил төсөөтэй опцион буюу бусад хязгаарлах нөхцөлтэйгээр уг шилжүүлсэн хөрөнгийг гуравдагч этгээдэд борлуулах практик боломжгүй учраас тэрхүү опцион эсвэл баталгаа нь тухайн шилжүүлсэн хөрөнгийг шилжүүлэн авагч борлуулахад саад учруулна. Харин шилжүүлэн авагч нь тухайн баталгаа буюу буцаах опционы дагуу төлбөрийг хүлээн авахын тулд уг шилжүүлсэн хөрөнгийг эзэмшсэн хэвээр байх юм. Ийм нөхцөлд шилжүүлэгч нь уг шилжүүлсэн хөрөнгийн хяналтыг өөртөө хадгалж үлдэнэ.

#### **Үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангах шилжүүлэлт**

МЗУ60. Байгууллага нь уг шилжүүлсэн хөрөнгийн хувьд төлөгдөх хүүний төлбөрийн зарим хэсгийг тэрхүү хөрөнгөнд үзүүлэх үйлчилгээний төлбөр байдлаар авах эрхийг хадгалан үлдэж болох юм. Үйлчилгээний гэрээг дуусгавар болгох буюу шилжүүлснээр байгууллагын өгөх уг хүүний төлбөрийн зарим хэсгийг тухайн үйлчилгээний хөрөнгө буюу үйлчилгээний өр төлбөрт хуваарилна. Байгууллага буцаан өгөхгүй хүүний төлбөрийн хэсэг нь зөвхөн хүүний СТРИП-ийн авлага юм. Жишээлбэл; байгууллага нь үйлчилгээний гэрээг дуусгавар болгох буюу шилжүүлснээр ямар ч хүүг өгөхгүй бол нийт хүүний тархалт нь зөвхөн хүүний СТРИП авлага болно. 29-р параграфыг мөрдөх зорилгын хувьд, тухайн үйлчилгээний хөрөнгийн үл хүлээн зөвшөөрсөн хэсэг ба хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа хэсэгт уг авлагын дансны үнийг хуваарилахын тулд тэрхүү үйлчилгээний хөрөнгийн бодит үнэ цэнэ болон зөвхөн хүүний СТРИП-ийн авлагыг ашигладаг. Үйлчилгээний хураамжийг тусгайлан заагаагүй эсвэл хүлээн авах үйлчилгээний хураамж нь үзүүлсэн үйлчилгээний хувьд тухайн байгууллагад зохих нөхөн төлбөр болж чадахааргүй бол тэрхүү үйлчилгээний үүргийн хувьд өр төлбөрийг түүний бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрнө.

МЗУ61. 29-р параграфыг мөрдөх зорилгын хувьд хүлээн зөвшөөрсөн хэвээр байх хэсэг болон үл хүлээн зөвшөөрөх хэсгийн бодит үнэ цэнийг тооцохдоо, байгууллага нь 30-р параграфтаас гадна 50-52-р параграф ба МЗУ101-МЗУ115-р параграфт заасан бодит үнэ цэнийн хэмжилтийн шаардлагуудыг мөрдөнө.

#### **Үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангахгүй шилжүүлэлт**

МЗУ62. 31-р параграфт дурдсан зарчмыг хэрхэн мөрдөхийг доор илэрхийлсэн. Шилжүүлсэн хөрөнгийн үл биелүүлэлтийн алдагдлын хувьд

байгууллагын гаргасан баталгаа нь уг шилжүүлсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхөд саад учруулж байвал тухайн байгууллага нь шилжүүлсэн хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалан үлдэх учраас тэрхүү шилжүүлсэн хөрөнгийг бүхэлд нь хүлээн зөвшөөрсөн хэвээр байх бөгөөд хүлээн авсан төлбөрийг өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.

### **Шилжүүлсэн хөрөнгө дэх цаашдын оролцоо**

МЗУ63. Байгууллага нь шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөрийг 32-р параграфын дагуу хэрхэн хэмжих жишээг доор харуулав.

#### *Бүх хөрөнгө*

(а) Шилжүүлсэн хөрөнгийн үл биелүүлэлтийн алдагдлыг төлөхөөр байгууллагын гаргасан баталгаа нь уг шилжүүлсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхөд түүний цаашдын оролцооны хэмжээгээр саад учруулж байвал тэрхүү шилжүүлсэн хөрөнгийг тухайн шилжүүлэлтийн өдөр дараах дүнгүүдийн аль багаар хэмжинэ: (i) хөрөнгийн дансны үнэ, ба (ii) тухайн шилжүүлэлтээр хүлээн авсан төлбөрөөс буцаан төлөхийг уг байгууллагаас шаардаж болох хамгийн их дүн (“баталгааны дүн”). Баталгааны дүн дээр уг баталгааны бодит үнэ цэнийг (энэ нь ихэвчлэн уг баталгааны төлөө хүлээн авсан төлбөр байдаг) нэмсэн дүнгээр холбогдох өр төлбөрийг анх хэмждэг. Цаг хугацааны хувь тэнцүүлсэн суурь (УСНББОУС 9-ийг үзнэ үү) ба аливаа үнэ цэнийн бууралтын гарзаар бууруулсан тухайн хөрөнгийн дансны үнэд үндэслэн уг баталгааны анхны бодит үнэ цэнийг дараагийн тайлант үеүдэд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

#### *Хорогдуулсан өртгөөр хэмжсэн хөрөнгө*

(б) Байгууллагын гаргасан буцаах опционы үүрэг эсвэл байгууллагын эзэмшиж буй дуудах опционы эрх нь шилжүүлсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхөөс сэргийлдэг бөгөөд байгууллага нь шилжүүлсэн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр хэмждэг бол холбогдох өр төлбөрийг түүний өртгөөр (өөрөөр хэлбэл, хүлээн авсан төлбөрийн дүнгээр) хэмжиж, тэрхүү өртөг ба опционы хугацаа дуусах өдрөөрх тухайн шилжүүлсэн хөрөнгийн нийт дансны үнэ хоорондох аливаа зөрүү болох хорогдуулгын хувьд уг өр төлбөрийн дансны үнийг тохируулна. Жишээлбэл; шилжүүлсэн өдөр уг хөрөнгийн хорогдуулсан өртөг ба нийт дансны үнэ нь 98ТН, хүлээн авсан төлбөр нь 95ТН байсан гэж үзье. Опционыг хэрэгжүүлэх өдөр тухайн хөрөнгийн хорогдуулсан өртөг нь 100ТН болно. Холбогдох өр төлбөрийн анхны дансны үнэ 95ТН бөгөөд тэрхүү 95ТН ба 100ТН-ийн хоорондох зөрүүг үр ашигт хүүний арга ашиглан ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Хэрэв опционыг хэрэгжүүлвэл холбогдох өр төлбөрийн дансны үнэ ба хэрэгжүүлэх үнийн хоорондох аливаа зөрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

*Бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгө*

- (в) Хэрэв байгууллагын хадгалан үлдсэн дуудах опционы эрх нь шилжүүлсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхөөс сэргийлдэг бөгөөд байгууллага нь шилжүүлсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмждэг бол тухайн хөрөнгийг түүний бодит үнэ цэнээр хэмжсэн хэвээр байна. Холбогдох өр төлбөрийг (i) хэрэв опцион нь мөнгөн ашигтай эсвэл мөнгөн ашиггүй<sup>12</sup> бол уг опционы хэрэгжүүлэх үнээс түүний цаг хугацааны үнэ цэнийг хассан дүнгээр, эсвэл (ii) хэрэв опцион нь мөнгөн алдагдалтай бол уг шилжүүлсэн хөрөнгийн бодит үнэ цэнээс тухайн опционы цаг хугацааны үнэ цэнийг хассан дүнгээр хэмжинэ. Холбогдох өр төлбөрийн ийм хэмжилтэнд тохируулга хийснээр тухайн хөрөнгө болон холбогдох өр төлбөрийн цэвэр дансны үнэ нь уг дуудах опционы эрхийн бодит үнэ цэнэтэй тэнцүү гэдгийг ханган магадалдаг. Жишээлбэл; суурь хөрөнгийн бодит үнэ цэнэ 80ТН, опционыг хэрэгжүүлэх үнэ 95ТН, опционы цаг хугацааны үнэ цэнэ 5ТН бол холбогдох өр төлбөрийн дансны үнэ нь 75ТН (80ТН - 5ТН), уг шилжүүлсэн хөрөнгийн дансны үнэ 80ТН (өөрөөр хэлбэл, түүний бодит үнэ цэнэ) болно.
- (г) Байгууллагын гаргасан буцаах опцион нь шилжүүлсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхөөс сэргийлдэг бөгөөд байгууллага нь уг шилжүүлсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмждэг бол холбогдох өр төлбөрийг тухайн опционы хэрэгжүүлэх үнэ дээр түүний цаг хугацааны үнэ цэнийг нэмсэн дүнгээр хэмжинэ. Байгууллага нь уг шилжүүлсэн хөрөнгийн бодит үнэ цэнийг опционы хэрэгжүүлэх үнээс илүү болгон өсгөх эрхгүй учраас тэрхүү хөрөнгийн бодит үнэ цэнээр хэмжилт нь уг бодит үнэ цэнэ ба опционы хэрэгжүүлэх үнийн аль багаар хязгаарлагдана. Ингэснээр тухайн хөрөнгө болон холбогдох өр төлбөрийн цэвэр дансны үнэ нь уг буцаах опционы үүргийн бодит үнэ цэнэтэй тэнцүү гэдгийг ханган магадалдаг. Жишээлбэл; хэрэв суурь хөрөнгийн бодит үнэ цэнэ 120ТН, опционы хэрэгжүүлэх үнэ 100ТН, уг опционы цаг хугацааны үнэ цэнэ 5ТН бол холбогдох өр төлбөрийн дансны үнэ нь 105ТН (100ТН+5ТН) ба тухайн хөрөнгийн дансны үнэ 100ТН (энэ тохиолдолд опционы хэрэгжүүлэх үнэтэй тэнцүү) байна.

Худалдан авсан дуудах опцион ба гаргасан буцаах опцион хэлбэртэй байгаа үнийн баталгаа нь шилжүүлсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхөөс сэргийлдэг бөгөөд байгууллага нь уг хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмждэг бол тухайн байгууллага нь тэрхүү шилжүүлсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмжсэн хэвээр байна. Холбогдох өр төлбөрийг (i) хэрэв дуудах опцион нь мөнгөн ашигтай эсвэл ашиггүй бол дуудах опционы хэрэгжүүлэх үнэ ба буцаах опционы бодит үнэ цэнийн нийлбэрээс уг дуудах опционы цаг хугацааны үнэ цэнийг хассан дүнгээр, эсвэл (ii) хэрэв дуудах опцион нь мөнгөн алдагдалтай бол тухайн хөрөнгийн бодит үнэ цэнэ ба буцаах опционы бодит үнэ цэнийн нийлбэрээс уг дуудах опционы цаг хугацааны үнэ цэнийг

---

<sup>12</sup> at the money put or call option-Мөнгөн ашиггүй буцаах опцион эсвэл дуудах опцион. Буцаах буюу дуудах опционы хэрэгжүүлэх үнэ нь суурь хөрөнгийн зах зээлийн үнэтэй тэнцүү бол мөнгөн ашиггүй гэнэ. Ред.Ч.Д.

хассан дүнгээр хэмжинэ. Холбогдох өр төлбөрт тохируулга хийснээр тухайн хөрөнгө ба холбогдох өр төлбөрийн цэвэр дансны үнэ нь уг байгууллагын эзэмшиж байгаа болон гаргасан опционуудын бодит үнэ цэнэтэй тэнцүү гэдгийг ханган магадалдаг. Жишээлбэл; байгууллага нь бодит үнэ цэнээр хэмждэг санхүүгийн хөрөнгөө шилжүүлэхийн хамтаар, үүнтэй нэгэн зэрэг 120ТН-ийн хэрэгжүүлэх үнэ бүхий дуудах опционыг худалдан авч, 80ТН-ийн хэрэгжүүлэх үнэ бүхий буцаах опционыг гаргасан гэж үзье. Мөн тухайн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь энэхүү шилжүүлэлтийн өдөр 100ТН байсан. Буцаах ба дуудах опционы цаг хугацааны үнэ цэнэ нь харгалзан 1ТН ба 5ТН байсан. Энэ тохиолдолд байгууллага нь хөрөнгийг 100ТН-ээр (тухайн хөрөнгийн бодит үнэ цэнээр), өр төлбөрийг 96ТН-ээр [(100ТН + 1ТН) – 5ТН] хүлээн зөвшөөрнө. Ингэснээр цэвэр хөрөнгийн үнэ цэнэ нь 4ТН болох бөгөөд энэ нь тухайн байгууллагын эзэмшиж байгаа болон гаргасан опционуудын бодит үнэ цэнэтэй тэнцүү болно.

### **Бүх шилжүүлэлт**

- МЗУ64. Шилжүүлэлтээр үүсэж буй шилжүүлсэн хөрөнгө, өр төлбөр ба тухайн шилжүүлэлттэй холбоотой шилжүүлэгчийн гэрээний эрх, үүргийн аль алиныг хүлээн зөвшөөрснөөр нэг эрх, үүргийг хоёр удаа хүлээн зөвшөөрөхөд хүргэхээр байвал тэрхүү санхүүгийн хөрөнгийн шилжүүлэлт нь үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангахгүй байх хэмжээгээр уг шилжүүлэгчийн гэрээний эрх, үүргийг үүсмэл хэрэглүүр гэж тусад нь тайлагнахгүй. Жишээлбэл; шилжүүлэгчийн хадгалан үлдсэн дуудах опцион нь тухайн санхүүгийн хөрөнгийн шилжүүлэлтийг борлуулалт гэж тайлагнахаас сэргийлдэг байж болох юм. Энэ тохиолдолд уг дуудах опционыг үүсмэл хөрөнгө гэж тусад нь хүлээн зөвшөөрөхгүй.
- МЗУ65. Санхүүгийн хөрөнгийн шилжүүлэлт нь үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангахгүй байх хэмжээгээр уг шилжүүлэн авагч нь тухайн шилжүүлсэн хөрөнгийг өөрийнхөө хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхгүй. Шилжүүлэн авагч нь төлсөн мөнгө буюу бусад төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх ба шилжүүлэгчээс авах авлагыг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Хэрэв шилжүүлэгч нь тухайн шилжүүлсэн бүх хөрөнгийн хяналтыг тогтмол дүнгээр (буцаан худалдан авах хэлцлийн дагуу гэх мэт) буцаан олж эзэмших эрх, үүргийн аль алиныг хадгалдаг бол шилжүүлэн авагч нь өөрийн авлагыг зээл эсвэл авлага гэж тайлагнаж болох юм.

### **Жишээ**

- МЗУ66. Энэ Стандартын үл хүлээн зөвшөөрөлтийн зарчмуудын мөрдөлтийг дараах жишээнд үлгэрчлэн харуулав.
- (а) Буцаан худалдан авах хэлцэл ба үнэт цаасны зээлдүүлэлт. Хэрэв санхүүгийн хөрөнгийг тогтмол үнээр эсвэл борлуулалтын үнэ дээр зээлдүүлэгчийн өгөөжийг нэмсэн дүнгээр буцаан худалдан авах хэлцлийн дагуу борлуулсан эсвэл тухайн шилжүүлэгчид түүнийг буцаан өгөх хэлцлийн дагуу зээлдүүлсэн бол уг шилжүүлэгч нь өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалан үлдэх учраас санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхгүй. Хэрэв шилжүүлэн



авагч нь тухайн хөрөнгийг борлуулах буюу барьцаалах эрхтэй бол шилжүүлэгч нь уг хөрөнгийг санхүүгийн байдлын тайландаа тухайлбал, зээлсэн хөрөнгө эсвэл буцаан худалдан авах авлага гэж дахин ангилна.

- (б) Буцаан худалдан авах хэлцэл ба үнэт цаасны зээлдүүлэлт – бараг ижил хөрөнгүүд. Хэрэв санхүүгийн хөрөнгөтэй ижил буюу бараг ижил хөрөнгийг тогтмол үнээр эсвэл борлуулалтын үнэ дээр зээлдүүлэгчийн өгөөжийг нэмсэн дүнгээр буцаан худалдан авах хэлцлийн дагуу санхүүгийн хөрөнгийг борлуулсан эсвэл тухайн шилжүүлэгчид ижил буюу бараг ижил хөрөнгийг буцаан өгөх хэлцлийн дагуу санхүүгийн хөрөнгийг зээлдсэн буюу зээлдүүлсэн бол уг шилжүүлэгч нь өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалан үлдэх учраас санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхгүй.
- (в) Буцаан худалдан авах хэлцэл ба үнэт цаасны зээлдүүлэлт – орлуулалтын эрх. Хэрэв тогтмол үнээр эсвэл борлуулалтын үнэ дээр зээлдүүлэгчийн өгөөжийг нэмсэн дүнгээр буцаан худалдан авах хэлцэл эсвэл үүнтэй ижил төсөөтэй үнэт цаасны зээлдүүлэх ажил гүйлгээ нь уг шилжүүлсэн хөрөнгөтэй ижил төсөөтэй бөгөөд тэнцүү бодит үнэ цэнэ бүхий хөрөнгийг тухайн буцаан худалдан авах өдөр орлуулсан өгөх эрхийг уг шилжүүлэн авагчид олгодог бол шилжүүлэгч нь өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалан үлдэх учраас тэрхүү буцаан худалдан авах буюу үнэт цаасыг зээлдүүлэх ажил гүйлгээний дагуу борлуулсан эсвэл зээлдүүлсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхгүй.
- (г) Бодит үнэ цэнээр тэргүүн ээлжинд буцаан худалдан авах эрх. Байгууллага нь санхүүгийн хөрөнгийг борлуулсан бөгөөд шилжүүлэн авагч нь уг хөрөнгийг дараагийн тайлант үед хэрэв борлуулах бол түүнийг тэр үеийн бодит үнэ цэнээр тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг зөвхөн хадгалж үлдсэн тохиолдолд байгууллага нь өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлэх учраас тухайн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.
- (д) Угаах борлуулалтын ажил гүйлгээ.<sup>13</sup> Санхүүгийн хөрөнгийг борлуулсны дараа богино хугацааны дотор буцаан худалдан авах ажил гүйлгээг зарим үед угаах борлуулалт гэж нэрлэдэг. Хэрэв анхны буюу борлуулах ажил гүйлгээ нь үл хүлээн зөвшөөрөлтийн шаардлагуудыг хангаж байвал ингэж буцаан худалдан авах нь тухайн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхөд саад учруулахгүй. Гэхдээ тухайн хөрөнгийг тогтмол үнээр эсвэл борлуулалтын үнэ дээр зээлдүүлэгчийн өгөөжийг нэмсэн дүнгээр буцаан худалдан авах

---

<sup>13</sup> Wash sale transaction-Угаах борлуулалтын ажил гүйлгээ. Жишээлбэл; татвар ногдуулах өндөр орлоготой боловч санхүүгийн хөрөнгийг борлуулахад алдагдал хүлээхээр байгаа тохиолдолд хөрөнгө оруулагч нь татварыг бууруулахын тулд угаах борлуулалтын аргыг хэрэглэдэг. Ред.Ч.Д.

хэлцлийн хамтаар санхүүгийн хөрөнгийг борлуулах хэлцлийг байгуулсан бол уг санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхгүй.

- (е) Их мөнгөн ашигтай буцаах опцион ба дуудах опцион. Шилжүүлэгч нь уг шилжүүлсэн санхүүгийн хөрөнгөө буцаан дуудан авч чадах бөгөөд дуудах опцион нь их мөнгөн ашигтай байгаа бол тухайн шилжүүлэгч нь өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалан үлдэх учраас ийм шилжүүлэлт нь үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангахгүй. Үүний адилаар, шилжүүлэн авагч нь уг санхүүгийн хөрөнгийг буцаан өгч чадах бөгөөд буцаах опцион нь их мөнгөн ашигтай байгаа бол шилжүүлэгч нь өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалан үлдэх учраас ийм шилжүүлэлт нь үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангахгүй.
- (ж) Их мөнгөн алдагдалтай буцаах опцион ба дуудах опцион. Шилжүүлэн авагчийн эзэмшиж буй их мөнгөн алдагдалтай буцаах опцион эсвэл шилжүүлэгчийн эзэмшиж буй их мөнгөн алдагдалтай дуудах опционд зөвхөн хамаарах уг шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө. Яагаад гэвэл, шилжүүлэгч нь өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн байна.
- (и) Их мөнгөн ашигтай ч биш, их мөнгөн алдагдалтай ч биш дуудах опционд хамаарах, шууд олж эзэмшиж болох хөрөнгө. Байгууллага нь зах зээлээс шууд олж эзэмшиж болох хөрөнгийн хувьд дуудах опционыг эзэмшиж байгаа бөгөөд уг опцион нь их мөнгөн ашигтай ч биш, их мөнгөн алдагдалтай ч биш бол тухайн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө. Яагаад гэвэл, байгууллага нь (i) өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалж үлдээгүй, бас шилжүүлээгүй, (ii) хяналтыг хадгалан үлдээгүй. Харин уг хөрөнгийг зах зээлээс шууд олж эзэмших боломжгүй бол байгууллага нь хөрөнгийн хяналтыг хадгалж үлдэх учраас тэрхүү дуудах опционд хамаарах тухайн хөрөнгийн дүнгийн хэмжээгээр үл хүлээн зөвшөөрөлтийг хязгаарлана.
- (к) Байгууллагын гаргасан, их мөнгөн ашигтай ч биш, их мөнгөн алдагдалтай ч биш дуудах опционд хамаарах, шууд олж эзэмших боломжгүй хөрөнгө. Байгууллага нь зах зээлээс шууд олж эзэмших боломжгүй санхүүгийн хөрөнгийг шилжүүлсэн бөгөөд их мөнгөн алдагдалтай биш тийм дуудах опционыг гаргасан бол уг гаргасан дуудах опционы үр дүнд тухайн байгууллага нь өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалан үлдэхгүй, бас шилжүүлэхгүй. Хэрэв дуудах опцион нь шилжүүлэн авагч уг хөрөнгийг борлуулахаас сэргийлэхүйц хангалттай үнэ цэнэтэй болвол байгууллага нь хөрөнгийн хяналтыг хадгалан үлдэх бөгөөд энэ тохиолдолд шилжүүлэгчийн цаашдын оролцооны хэмжээгээр тухайн хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн хэвээр байна (МЗУ64-р параграфыг үзнэ үү). Хэрэв дуудах опцион нь шилжүүлэн авагч уг хөрөнгийг борлуулахаас сэргийлэхүйц хангалттай үнэ цэнэгүй бол байгууллага нь хөрөнгийн хяналтыг шилжүүлэх бөгөөд энэ тохиолдолд тухайн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

- (л) Бодит үнэ цэнийн буцаах опцион эсвэл дуудах опционд, эсвэл буцаан худалдан авах форвард хэлцэлд хамаарах хөрөнгө. Буцаан худалдан авах өдөр тухайн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэтэй тэнцүү байх, хэрэгжүүлэх буюу буцаан худалдан авах үнэ бүхий буцаах опцион эсвэл дуудах опционд, эсвэл буцаан худалдан авах форвард гэрээний хэлцэлд зөвхөн хамаарах санхүүгийн хөрөнгийн шилжүүлэлт нь өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлдэг учраас ийм шилжүүлэлтийг үл хүлээн зөвшөөрнө.
- (м) Мөнгөөр барагдуулах дуудах эсвэл буцаах опцион. Цэвэр дүнгээр нь мөнгөөр барагдуулах буцаах опцион эсвэл дуудах опционд, эсвэл буцаан худалдан авах форвард хэлцэлд хамаарах санхүүгийн хөрөнгийн шилжүүлэлт нь өмчлөлийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалж үлддэг эсвэл шилжүүлдэг эсэхийг тодорхойлохын тулд байгууллага нь ийм шилжүүлэлтийг үнэлнэ. Хэрэв байгууллага нь уг шилжүүлсэн хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалан үлддэггүй бол байгууллага нь тухайн шилжүүлсэн хөрөнгийн хяналтыг хадгалан үлдсэн эсэхийг тодорхойлно. Уг буцаах опцион эсвэл дуудах опцион, эсвэл буцаан худалдан авах форвард хэлцлийг цэвэр дүнгээр нь мөнгөөр барагдуулж байгаа нь тухайн байгууллага хяналтыг шилжүүлсэн гэсэн утгыг шууд илэрхийлэхгүй (МЗУ59-р параграф болон дээрх (ж), (и), (к) заалтыг үзнэ үү).
- (н) Зарим хэсгийг буцаан худалдан авах нөхцөл. Зарим хэсгийг буцаан худалдан авах нөхцөл гэдэг нь уг шилжүүлсэн хөрөнгийг тодорхой хязгаарлалттайгаар буцаан нэхэмжлэх эрхийг байгууллагад олгодог нөхцөлт бус буцаан худалдан авалтын (дуудах) опцион юм. Хэрэв ийм опцион нь өмчлөлтэй холбоотой бараг бүх эрсдэл ба өгөөжийг байгууллага хадгалан үлдэхгүй, бас шилжүүлэхгүй байхад хүргэж байвал энэ нь зөвхөн буцаан худалдан авахад хамаарах дүнгийн хэмжээгээр (шилжүүлэн авагч нь уг хөрөнгийг борлуулж чадахгүй гэж үзэх) үл хүлээн зөвшөөрөлтөнд саад учруулдаг. Жишээлбэл; зээлийн хөрөнгүүдийн дансны үнэ ба тэдгээрийн шилжүүлэлтийн орлого нь 100,000ТН бөгөөд аль ч зээлийг буцаан дуудаж чадах боловч буцаан худалдан авч болох зээлийн нийт дүн нь 10,000ТН-ээс хэтрэхгүй гэж үзье. Тэгвэл 90,000ТН-ийн зээл нь үл хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангана.
- (о) Үлдэх хөрөнгийн опцион. Уг шилжүүлсэн хөрөнгөнд үйлчилгээ үзүүлдэг байгууллага, тухайлбал шилжүүлэгч нь үйлчилгээнээс олж буй үр өгөөжтэй харьцуулахад үйлчилгээний өртөг зардал их болох тийм тодорхой түвшин хүртэл тэдгээр эргэлтэнд байгаа хөрөнгийн дүн багассан тохиолдолд тэрхүү шилжүүлсэн хөрөнгөөс үлдсэн хэсгийг худалдан авахын тулд үлдэх хөрөнгийн опционыг эзэмшдэг байж болно. Хэрэв ийм үлдэх хөрөнгийн опцион нь өмчлөлтэй холбоотой бараг бүх эрсдэл ба өгөөжийг уг байгууллага хадгалан үлдэхгүй, бас шилжүүлэхгүй байхад хүргэх бөгөөд шилжүүлэн авагч нь тухайн хөрөнгийг борлуулж чадахгүй бол энэ

нь зөвхөн тэрхүү дуудах опционд хамаарах хөрөнгийн дүнгийн хэмжээгээр үл хүлээн зөвшөөрөлтөнд саад учруулна.

- (п) Хадгалан үлдсэн тэргүүн бус ээлжийн эрхтэй хувь оролцоо ба зээлийн баталгаа. Байгууллага нь уг шилжүүлсэн хөрөнгийн хувьд хадгалан үлдсэн өөрийн зарим буюу бүх хувь оролцоогоо тэргүүн бус ээлжийн эрхтэй болгосноор зээлийн сайжруулалтыг тухайн шилжүүлэн авагчид бүрдүүлж өгч болох юм. Үүнтэй адилаар, байгууллага нь ямар нэг хязгаарлалтгүй эсвэл тохиролцсон дүнгээр хязгаарлагдах зээлийн баталгаа хэлбэрээр зээлийн сайжруулалтыг тухайн шилжүүлэн авагчид бүрдүүлэн өгч болно. Хэрэв байгууллага нь уг шилжүүлсэн хөрөнгийн өмчлөлтэй холбоотой бараг бүх эрсдэл ба өгөөжийг хадгалан үлдсэн бол тухайн хөрөнгийг бүхэлд нь хүлээн зөвшөөрсөн хэвээр байна. Хэрэв байгууллага нь өмчлөлтэй холбоотой бараг бүх биш боловч зарим эрсдэл ба өгөөжийг хадгалан үлдсэн бөгөөд хяналтыг хадгалан үлдсэн бол тухайн байгууллагаас төлөхийг шаардаж болох тэрхүү мөнгө буюу бусад хөрөнгийн дүнгийн хэмжээгээр үл хүлээн зөвшөөрөлтийг хязгаарлана.
- (р) Нийт өгөөжийн своп. Байгууллага нь шилжүүлэн авагчид санхүүгийн хөрөнгийг борлуулах ба нийт өгөөжийн свопын гэрээг түүнтэй байгуулж болох юм. Ингэснээр шилжүүлэн авагч нь тогтмол төлбөр эсвэл хувьсах түвшний төлбөр хүлээн авсаны хариуд уг суурь хөрөнгөөс бий болох бүх хүүний төлбөрийн мөнгөн гүйлгээг тухайн байгууллагад буцаан өгөх бөгөөд тэрхүү суурь хөрөнгийн бодит үнэ цэнийн аливаа өсөлт, бууралтыг тэрхүү байгууллага хариуцна. Ийм тохиолдолд уг хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлтийг бүхэлд нь хориглодог.
- (с) Хүүний түвшний своп. Байгууллага нь шилжүүлэн авагчид тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгийг шилжүүлж, уг шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн үндсэн дүнтэй тэнцүү нэрлэсэн дүнд үндэслэн тооцогдох хувьсах хүүг төлөх ба тогтмол хүүг хүлээн авах хүүний түвшний свопын гэрээг тухайн шилжүүлэн авагчтай байгуулж болох юм. Ийм свопын төлбөр нь уг шилжүүлсэн хөрөнгөтэй холбоотойгоор хийгдэх төлбөрөөс нөхцөлт хамааралтай биш бол хүүний түвшний своп нь уг шилжүүлсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхөд саад учруулахгүй.
- (т) Хорогдох хүүний түвшний своп. Байгууллага нь цаг хугацааны явцад төлж барагдах, тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгийг тухайн шилжүүлэн авагчид шилжүүлж, нэрлэсэн дүнд үндэслэн тооцогдох хувьсах хүүг төлөх ба тогтмол хүүг хүлээн авах тийм хорогдох хүүний түвшний свопын гэрээг уг шилжүүлэн авагчтай байгуулж болох юм. Хэрэв свопын нэрлэсэн дүн нь эргэлтэнд байгаа, уг шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн үндсэн дүнтэй дурын хугацаанд тэнцүү байхын тулд хорогдон буурдаг бол тухайн своп нь урьдчилан төлөлтийн ихэнх эрсдлийг ерөнхийдөө тэрхүү байгууллага хадгалан үлдэхэд хүргэнэ. Ийм тохиолдолд

байгууллага нь уг шилжүүлсэн хөрөнгийг бүгдийг нь, эсвэл өөрийн цаашдын оролцооны хэмжээгээр зарим хэсгийг хүлээн зөвшөөрсөн хэвээр байна. Харин эсрэгээр, свопын нэрлэсэн дүнгийн хорогдуулга нь эргэлтэнд байгаа, уг шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн үндсэн дүнтэй харилцан холбоогүй бол ийм своп нь тухайн хөрөнгийн урьдчилан төлөлтийн эрсдлийг байгууллага хадгалан үлдэхэд хүргэхгүй. Иймээс хэрэв свопын төлбөр нь шилжүүлсэн хөрөнгийн хувьд хийгдэж буй төлбөрөөс нөхцөлт хамааралтай биш бөгөөд своп нь уг шилжүүлсэн хөрөнгийн өмчлөлийн аливаа бусад мэдэгдэхүйц эрсдэл ба урамшууллыг тухайн байгууллага хадгалан үлдэхэд хүргэдэггүй бол своп нь тэрхүү шилжүүлсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхөд саад учруулахгүй.

- МЗУ67. Байгууллага нь санхүүгийн хөрөнгийн зарим хэсэгт цаашдын оролцоотой байх тохиолдолд цаашдын оролцооны арга хандлагыг хэрхэн хэрэглэхийг энэ параграфт үлгэрчлэн харуулав.

Байгууллага нь урьдчилан төлөгдөх зээлүүдийн багцтай бөгөөд түүний нэрлэсэн болон үр ашигт хүүний хувь 10, үндсэн дүн ба хорогдуулсан өртөг нь 10,000ТН байсан. Тус байгууллага нь зээлийн авлагаа шилжүүлэх ажил гүйлгээ хийж, 9,115ТН хүлээн авсан бөгөөд шилжүүлэн авагч нь энэхүү төлбөрийнхөө хариуд 9,000ТН-ийн зээлийн үндсэн дүн, түүнчлэн тэрхүү дүнгийн 9.5 хувийн хүүний аливаа цуглуулалтыг хүлээн авах эрхтэй болсон. Байгууллага нь 1,000ТН-ийн үндсэн төлбөр, түүний 10 хувийн хүү, түүнчлэн дээрх 9,000ТН-ийн үндсэн төлбөрийн 0.5 хувийн үлдэх хүүг авах эрхийг хадгалан үлдсэн. Урьдчилсан төлбөрийн цуглуулалтыг тухайн байгууллага ба шилжүүлэн авагч нь 1:9 гэсэн харьцаагаар хуваарилан авах боловч аливаа үл биелүүлэлтийг (үл төлөлтийг) уг байгууллагын мэдэлд байгаа 1,000ТН-ийг дуусах хүртэл түүнээс хасаж тооцно. Энэхүү ажил гүйлгээний өдөр зээлүүдийн бодит үнэ цэнэ нь 10,100ТН, харин 0.5 хувийн хүүний тархалтын (нэмэгдлийн) бодит үнэ цэнэ нь 40ТН байсан.

Байгууллага нь өмчлөлийн зарим мэдэгдэхүйц эрсдэл, өгөөжийг (жишээлбэл; урьдчилан төлөлтийн мэдэгдэхүйц эрсдэл) шилжүүлсэн боловч мөн зарим мэдэгдэхүйц эрсдэл, өгөөжийг (хадгалан үлдсэн тэргүүн бус ээлжийн хувь оролцооны улмаас) хадгалан үлдсэн ба хяналтыг хадгалан үлдсэн байна гэж тодорхойлсон. Иймээс байгууллага нь цаашдын оролцооны арга хандлагыг хэрэглэнэ.

Энэхүү Стандартыг мөрдөхийн тулд байгууллага нь уг ажил гүйлгээг дараах байдлаар шинжилнэ: (а) шууд хамааралтай бүрэн оролцоо бүхий 1,000ТН-ийн хувь оролцоог хадгалан үлдсэн, түүнчлэн (б) зээлийн алдагдлын хувьд тухайн шилжүүлэн авагчид зээлийн сайжруулалт бүрдүүлж өгөхийн тулд өөрийн энэхүү хадгалан үлдсэн хувь оролцоогоо тэргүүн бус ээлжийн эрхтэй болгосон.

Уг хүлээн авсан 9,115ТН-ийн төлбөрөөс 9,090ТН (10,100ТН х 90 хувь) нь 90 хувийн шууд хамааралтай бүрэн оролцооны төлбөрийг илэрхийлнэ гэж тухайн байгууллага тооцоолсон. Хүлээн авсан төлбөрөөс үлдсэн хэсэг (25ТН) нь зээлийн алдагдлын хувьд тухайн шилжүүлэн авагчид зээлийн сайжруулалт бүрдүүлж өгөхийн тулд өөрийн хадгалан үлдсэн хувь оролцоогоо тэргүүн бус ээлжийн эрхтэй болгосны төлөө хүлээн авсан төлбөрийг илэрхийлнэ. Мөн 0.5 хувийн хүүний тархалт (нэмэгдэл) нь уг зээлийн сайжруулалтын хувьд хүлээн авсан төлбөрийг илэрхийлнэ. Иймээс зээлийн сайжруулалтын төлөө хүлээн авсан нийт төлбөр нь 65ТН (25ТН+40ТН) болно.

Байгууллага нь мөнгөн гүйлгээнийхээ 90 хувийг борлуулсны олз, гарзыг тооцоолно. Шилжүүлсэн 90 хувь ба хадгалан үлдсэн 10 хувийн тус бүрийн бодит үнэ цэнийг уг шилжүүлэлтийн өдрөөр тогтоох боломжгүй байсан гэж үзвэл байгууллага нь 30-р параграфын дагуу тухайн хөрөнгийн дансны үнийг доорх байдлаар хуваарилна:

	<i>Тооцоолсон бодит үнэ цэнэ</i>	<i>Хувийн жин</i>	<i>Хуваарилсан дансны үнэ</i>
Шилжүүлсэн хэсэг	9,090	90%	9,000
Хадгалан үлдсэн хэсэг	1,010	10%	1,000
<b>Дүн</b>	<b>10,100</b>		<b>10,000</b>

Байгууллага нь тухайн шилжүүлсэн хэсэгт хуваарилсан дансны үнийг уг хүлээн авсан төлбөрөөс хассанаар мөнгөн гүйлгээний 90 хувийг борлуулсны олз, гарзыг тооцоолно, өөрөөр хэлбэл энэ нь 90ТН (9,090ТН- 9,000ТН) байна. Байгууллагын хадгалан үлдсэн хэсгийн дансны үнэ нь 1,000ТН болно.

Түүнчлэн, байгууллага нь өөрийн хадгалан үлдсэн хувь оролцоог зээлийн алдагдлын улмаас тэргүүн бус ээлжийн эрхтэй болгосны үр дүн болох цаашдын оролцоог хүлээн зөвшөөрнө. Иймээс байгууллага нь 1,000ТН-ийн хөрөнгө (тэргүүн бус ээлжийн эрхийн улмаас хүлээн авахгүй байж болох мөнгөн гүйлгээний хамгийн их дүн) ба 1,065ТН-ийн холбогдох өр төлбөрийг (тэргүүн бус ээлжийн эрхийн улмаас хүлээн авахгүй байж болох мөнгөн гүйлгээний хамгийн их дүн 1,000ТН дээр, тэргүүн бус ээлжийн эрхтэй болсны төлбөр 65ТН-ийн бодит үнэ цэнийг нэмсэн дүн) хүлээн зөвшөөрнө. Байгууллага нь уг ажил гүйлгээг дараах байдлаар тайлагнахын тулд дээрх бүх мэдээллийг ашиглана:

	<i>Дебит</i>	<i>Кредит</i>
Анх байсан хөрөнгө	-	9,000
Тэргүүн бус ээлжийн эрхтэй болголт буюу үлдэх хувь оролцооны хувьд хүлээн зөвшөөрсөн хөрөнгө	1,000	-
Хүүний тархалт (нэмэгдэл) хэлбэрээр хүлээн авах төлбөрийг илэрхийлэх хөрөнгө	40	-

Ашиг, алдагдал (шилжүүлэлтийн олз)	-	90
Өр төлбөр	-	1,065
Хүлээн авсан мөнгө	9,115	-
<b>Дүн</b>	<b>10,155</b>	<b>10,155</b>

Энэхүү ажил гүйлгээний дараа, тухайн хөрөнгийн дансны үнэ нь 2,040ТН байх бөгөөд уг хадгалан үлдсэн хэсэгт хуваарилсан өртөг болох 1,000ТН ба байгууллага өөрийн хадгалан үлдсэн хэсгийг зээлийн алдагдалд зориулан тэргүүн бус ээлжийн эрхтэй болгосны үр дүнд түүний нэмэлт цаашдын оролцоог илэрхийлэх 1,040ТН-ээс (үүнд 40ТН-ийн хүүний тархалт багтсан) бүрдэнэ.

Дараагийн тайлант үеүдэд байгууллага нь зээлийн сайжруулалтын хувьд хүлээн авах төлбөрийг (65ТН) цаг хугацаагаар хувь тэнцүүлэн хүлээн зөвшөөрөх бөгөөд уг хүлээн зөвшөөрсөн хөрөнгөнд үр ашигт хүүний аргаар тооцогдох хүүг хуримтлуулж, тэрхүү хүлээн зөвшөөрсөн хөрөнгөнд хамаарах аливаа үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрнө. Ийм үнэ цэнийн бууралтын гарзын жишээ болгон дараагийн жилд уг суурь зээлийн хөрөнгийн хувьд 300ТН-ийн үнэ цэнийн бууралтын гарз гарсан гэж үзье. Байгууллага нь уг хүлээн зөвшөөрсөн хөрөнгийг 600ТН-ээр (үүнээс 300ТН нь түүний хадгалан үлдсэн хувь оролцоонд хамаарах ба 300ТН нь тухайн хадгалан үлдсэн хувь оролцоогоо ийм үнэ цэнийн бууралтын гарзад зориулан тэргүүн бус ээлжийн эрхтэй болгосноор үүссэн цаашдын нэмэлт оролцоонд хамаарна) бууруулж, хүлээн зөвшөөрсөн өр төлбөрөө 300ТН-ээр бууруулна. Цэвэр үр дүн болох 300ТН-ийн үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдалд тусгана.

*Санхүүгийн хөрөнгийн ердийн нөхцлөөр худалдан авалт буюу борлуулалт*

- МЗУ68. Санхүүгийн хөрөнгийн ердийн нөхцлөөр худалдан авалт буюу борлуулалтыг МЗУ70 ба МЗУ71-р параграфт заасан, арилжааны өдрийн нягтлан бодох бүртгэл эсвэл барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийн аль нэгийг ашигласнаар хүлээн зөвшөөрнө. 10-р параграфт тодорхойлсон, санхүүгийн хөрөнгийн нэг ангид хамаарах санхүүгийн хөрөнгүүдийн бүх худалдан авалт ба борлуулалтын хувьд тухайн сонгосон аргаа тууштай мөрдөнө. Энэ зорилгын хувьд, худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй хөрөнгө нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилдаг хөрөнгөөс тусдаа ангилал болох юм.
- МЗУ69. Гэрээний үнэ цэнийн өөрчлөлтийг цэвэр дүнгээр барагдуулахыг шаарддаг буюу зөвшөөрдөг гэрээ нь ердийн нөхцлөөр хийгдэх гэрээнд хамаарахгүй. Харин ийм гэрээг арилжааны өдөр ба барагдуулалтын өдрийн хоорондох хугацаанд үүсмэл хэрэглүүр гэж тайлагнана.
- МЗУ70. Арилжааны өдөр гэдэг нь байгууллага хөрөнгийг худалдан авах эсвэл борлуулах хариуцлагыг өөрөө хүлээсэн өдөр юм. Арилжааны өдрийн

нягтлан бодох бүртгэл нь дараах зүйлсэд хамаарна: (а) уг арилжааны өдрөөр хүлээн авах хөрөнгө ба түүний хувьд төлөх өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт, (б) тухайн арилжааны өдрөөрх борлуулсан хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлт, данснаас хасалтын аливаа олз буюу гарзын хүлээн зөвшөөрөлт, төлбөрийн хувьд худалдан авагчаас авах авлагын хүлээн зөвшөөрөлт. Эрх шилжих уг барагдуулалтын өдөр хүртэл хөрөнгө, түүнчлэн холбогдох өр төлбөрийн хувьд хүүг ерөнхийдөө хуримтлуулж эхлэхгүй.

МЗУ71. Барагдуулалтын өдөр гэдэг нь тухайн байгууллага хөрөнгийг хүргэн нийлүүлэх эсвэл хүлээн авах өдөр юм. Барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэл нь дараах зүйлсэд хамаарна: (а) байгууллага хүлээн авсан өдөр хөрөнгийг хүлээн зөвшөөрөлт, (б) байгууллага хүргэн нийлүүлсэн өдөр хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөлт болон данснаас хасалтын аливаа олз буюу гарзын хүлээн зөвшөөрөлт. Барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийг мөрдөх тохиолдолд байгууллага нь уг арилжааны өдөр ба барагдуулалтын өдрийн хоорондох хугацаанд хүлээн авсан хөрөнгийн бодит үнэ цэнийн аливаа өөрчлөлтийг тухайн олж эзэмшсэн хөрөнгийг тайлагнахтай ижил арга замаар тайлагнана. Өөрөөр хэлбэл, өртөг буюу хорогдуулсан өртгөөр хэмжсэн хөрөнгийн хувьд үнэ цэнийн өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөхгүй; ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө гэж ангилсан хөрөнгийн хувьд үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө; борлуулах боломжтой гэж ангилсан хөрөнгийн хувьд үнэ цэнийн өөрчлөлтийг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө.

*Санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт (41-44-р параграф)*

МЗУ72. Зээлдэгч нь дараах аль нэг байдлаар санхүүгийн өр төлбөрийг (эсвэл түүний хэсгийг) барагдуулдаг:

- (а) Зээлдүүлэгчид ихэвчлэн мөнгөөр, түүнчлэн бусад санхүүгийн хөрөнгө, бараа, үйлчилгээгээр төлбөр хийснээр өр төлбөрийг барагдуулах; эсвэл
- (б) Хууль эрх зүйн процессоор эсвэл зээлдүүлэгч зөвшөөрснөөр тухайн өр төлбөрийн (эсвэл түүний хэсгийн) талаархи анхдагч хариуцлагаас хууль ёсоор чөлөөлөгдсөн. (Хэрэв зээлдэгч нь баталгаа гаргасан бол тэр нөхцөл нь хангагдсан байж болох юм.)

МЗУ73. Өрийн хэрэглүүрийн гаргагч нь уг хэрэглүүрээ буцаан худалдаж авсан бол хэдийгээр гаргагч нь тухайн хэрэглүүрийн хувьд зах зээлийн тоглогч байсан эсвэл ойрын ирээдүйд түүнийг буцаан борлуулах зорилготой байсан ч гэсэн өр төлбөрийг барагдуулсан гэж үзнэ.

МЗУ74. Гуравдагч талд, үүн дотроо итгэлцлийн санд төлбөр хийх (үүнийг зарим үед “мөн чанарын хувьд барагдуулалт” гэж нэрлэдэг) нь хуулийн дагуу чөлөөлөгдөх заалтгүй тохиолдолд зээлдүүлэгчийн өмнө хүлээсэн анхдагч үүргээс тухайн зээлдэгчийг чөлөөлөхгүй.



- МЗУ75. Зээлдэгч нь түүний үүргийг хариуцах гуравдагч талд төлбөр хийсэн бөгөөд тэрхүү өрийн үүргийг гуравдагч тал хариуцах болсныг өөрийн зээлдүүлэгчид мэдэгдсэн ч гэсэн тухайн зээлдэгч нь МЗУ72(б) параграфт заасан нөхцөл хангагдахаас бусад тохиолдолд уг өрийн үүргийг үл хүлээн зөвшөөрөхгүй. Хэрэв зээлдэгч нь түүний үүргийг хариуцах гуравдагч талд төлбөр хийсэн бөгөөд өөрийн зээлдүүлэгчээс хууль ёсны дагуу чөлөөлөгдсөн бол тухайн зээлдэгч нь өрийг барагдуулсан гэж үзнэ. Гэвч зээлдэгч нь тухайн өрийн төлбөрийг гуравдагч талд эсвэл өөрийн анхны зээлдүүлэгчид шууд төлөхийг зөвшөөрсөн бол тухайн зээлдэгч нь уг гуравдагч талд төлөх шинэ өрийн үүргийг хүлээн зөвшөөрнө.
- МЗУ76. Гуравдагч тал нь байгууллагын үүргийг хариуцсан бөгөөд үүний хариуд тухайн байгууллага нь тэрхүү гуравдагч талд төлбөр төлөхгүй эсвэл зөвхөн нэрлэсэн төлбөр төлөхөөр бол уг байгууллага нь энэ Стандартын үл хүлээн зөвшөөрөлтийн шаардлагууд, түүнчлэн УСНББОУС 23-ын 84-87-р параграфыг мөрдөнө.
- МЗУ77. Зээлдүүлэгч нь түүнд улсын секторын байгууллагын төлөх өрийг цуглуулан авах өөрийн эрхээс зарим үед татгалздаг. Жишээлбэл; үндэсний засгийн газар нь орон нутгийн засаг захиргааны төлөх зээлийг хүчингүй болгож болох юм. Өрийн ийм хүчингүй болголт нь тухайн зээлдүүлэгчид төлөх зээлдэгчийн өрийн хууль ёсны чөлөөлөлт болно. Арилжааны бус ажил гүйлгээний нэг хэсэг байдлаар байгууллагын үүргийг хүчингүй болгосон тохиолдолд тухайн байгууллага нь энэ Стандартын үл хүлээн зөвшөөрөлтийн шаардлагууд, түүнчлэн УСНББОУС 23-ын 84-87-р параграфыг мөрдөнө.
- МЗУ78. Шүүхийн журмаар эсвэл зээлдүүлэгчийн зөвшөөрснөөр өрөөс хууль ёсоор чөлөөлөгдөх нь өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөхөд хүргэдэг боловч тухайн шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн хувьд 17-39-р параграфт заасан үл хүлээн зөвшөөрөлтийн шалгуур хангагдахгүй тохиолдолд байгууллага нь шинэ өр төлбөрийг хүлээн зөвшөөрч болох юм. Хэрэв тэдгээр шалгуурууд хангагдахгүй бол уг шилжүүлсэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд байгууллага нь тэрхүү шилжүүлсэн хөрөнгөтэй холбоотойгоор шинэ өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.
- МЗУ79. 42-р параграфын зорилгын хувьд тухайн шинэ нөхцлийн дагуу төлөх мөнгөн гүйлгээний, үүн дотроо хүлээн авсан аливаа хураамжийг хассан аливаа төлөх цэвэр хураамжийн уг анхны үр ашигт хүүний түвшнээр дискаунтчилсан өнөөгийн үнэ цэнэ нь тэрхүү анхны санхүүгийн өр төлбөрийн үлдэж буй мөнгөн гүйлгээний дискаунтчилсан өнөөгийн үнэ цэнээс наад зах нь 10 хувиар зөрүүтэй бол тэдгээр нөхцлүүдийг мэдэгдэхүйц өөр байна гэж үзнэ. Хэрэв өрийн хэрэглүүрүүдийн солилцоо буюу нөхцлийн өөрчлөлтийг өр төлбөрийн барагдуулалттай нэгэн адилаар тайлагнадаг бол гарсан аливаа зардал буюу хураамжийг тухайн барагдуулалтын олз, гарзын нэг хэсэг байдлаар хүлээн зөвшөөрнө. Хэрэв солилцоо буюу нөхцлийн өөрчлөлтийг өр төлбөрийн барагдуулалт байдлаар тайлагнадаггүй бол гарсан аливаа зардал буюу хураамжаар

тухайн өр төлбөрийн дансны үнийг тохируулах бөгөөд тэрхүү өөрчлөгдсөн өр төлбөрийн үлдэх хугацааны туршид хорогдуулна.

МЗУ80. Зарим тохиолдолд зээлдүүлэгч нь төлбөр төлөх одоогийн үүргээс зээлдэгчийг чөлөөлдөг боловч тэрхүү өрийг төлөх анхдагч хариуцлагыг хүлээсэн тал нь үүргээ биелүүлэхгүй бол тухайн зээлдэгч нь төлөх баталгааны үүргийг хариуцан хүлээдэг. Ийм тохиолдолд зээлдэгч нь:

- (а) Уг баталгааны хувьд өөрийн хүлээх үүргийн бодит үнэ цэнэд үндэслэн шинэ санхүүгийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө; ба
- (б) Дараах хоёр дүнгийн зөрүүд үндэслэн олз эсвэл гарзыг хүлээн зөвшөөрнө: (i) төлсөн аливаа шимтгэл, ба (ii) анхны санхүүгийн өр төлбөрийн дансны үнээс шинэ санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийг хассан дүн.

### **Хэмжилт (45-86-р параграф)**

*Арилжааны бус орлогын ажил гүйлгээ*

МЗУ81. Арилжааны бус орлогын ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгө, өр төлбөрийн анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийг УСНББОУС 23-д авч үздэг. Арилжааны бус орлогын ажил гүйлгээний үр дүн болох хөрөнгө нь гэрээний ба гэрээний бус хэлцлийн аль алинаас үүсдэг (УСНББОУС 28-ын МЗУ20, МЗУ21-р параграфыг үзнэ үү). Эдгээр хөрөнгө нь гэрээний хэлцлээс үүссэн ба санхүүгийн хэрэглүүрийн тодорхойлолтыг өөр бусад байдлаар хангадаг тохиолдолд түүнийг:

- (а) анх УСНББОУС 23-ын дагуу хүлээн зөвшөөрнө;
- (б) анх доорх байдлаар хэмжинэ:
  - (i) УСНББОУС 23-ын зарчмуудыг ашиглан бодит үнэ цэнээр; ба
  - (ii) тухайн хөрөнгийг дараагийн тайлант үед ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжихээс өөр бусад байдлаар хэмждэг бол энэ Стандартын 45-р параграфын дагуу уг санхүүгийн хөрөнгийн олж эзэмшилтэнд шууд хамаарах гүйлгээний зардлыг харгалзан.

(энэ Стандартыг дагалдах ҮЖ46-ҮЖ50-р параграфыг үзнэ үү.)

*Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн анхны хэмжилт (45-р параграф)*

МЗУ82. Анх хүлээн зөвшөөрөх үед санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ нь үндсэндээ түүний ажил гүйлгээний үнэ (өөрөөр хэлбэл, өгсөн эсвэл хүлээн авсан төлбөрийн бодит үнэ цэнэ, мөн МЗУ108-р параграфыг үзнэ үү). Гэвч өгсөн эсвэл хүлээн авсан төлбөрийн зарим хэсэг нь уг санхүүгийн хэрэглүүрээс өөр бусад зүйлсэд хамаарах бол үнэлгээний арга зүйг ашиглан тухайн санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг хэмжинэ (МЗУ106-МЗУ112-р параграфыг үзнэ үү). Жишээлбэл; хүүгүй, урт хугацаат зээл эсвэл авлагын бодит үнэ цэнийг адил зээлийн зэрэглэл бүхий ижил төсөөтэй хэрэглүүрийн (валют, нөхцөл, хүүний түвшний

төрөл болон бусад хүчин зүйлсийн хувьд ижил төсөөтэй) зах зээлийн давамгайлах хүүний түвшинг ашиглан дискаунтчилсан, ирээдүйн бүх мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээр тооцоолж болно. Зээлдүүлсэн аливаа нэмэлт дүн нь өөр ямар нэг төрлийн хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангахгүй бол зардал буюу орлогын бууралт болно.

МЗУ83. Байгууллага нь зах зээлийн түвшнээс бага хүүтэй (жишээлбэл; ижил төсөөтэй зээлийн зах зээлийн хүүний түвшин 8 хувь байх үед 5 хувийн хүүтэй) зээл гаргадаг бөгөөд үүнийхээ нөхөн төлбөр болгон урьдчилсан хураамж авдаг бол тухайн байгууллага нь уг зээлийг түүний бодит үнэ цэнээр, өөрөөр хэлбэл хүлээн авсан хураамжаа хассан цэвэр дүнгээр хүлээн зөвшөөрнө. Байгууллага нь энэхүү хөнгөлөлтийг үр ашигт хүүний арга ашиглан ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

#### *Хөнгөлөлттэй зээл*

МЗУ84. Хөнгөлөлттэй зээл гэдэг нь зах зээлийн нөхцлөөс доогуур нөхцөлтэйгээр байгууллагын хүлээн авсан буюу олгосон зээл юм. Байгууллагын олгодог хөнгөлөлттэй зээлийн жишээнд хөгжиж буй орнуудад олгосон зээл, жижиг аж ахуйд олгосон зээл, их дээд сургуулийн боловсролын шалгуур хангасан оюутнуудад олгосон оюутны зээл, бага орлоготой өрхөд олгосон өрхийн зээл хамаардаг. Байгууллага нь хөнгөлөлттэй зээлийг тухайлбал, хөгжлийн агентлаг ба бусад засгийн газрын байгууллагаас авч болох юм.

МЗУ85. Хөнгөлөлттэй зээлийн олголт буюу хүлээн авалтыг байгууллагын авах буюу төлөх өрийн чөлөөлөлтөөс ялган тодорхойлдог. Ингэж ялган тодорхойлох нь тухайн зээлийн дараагийн тайлант үеийн хэмжилт буюу үл хүлээн зөвшөөрөлтийн нэг хэсэг байдлаар биш, харин анх хүлээн зөвшөөрөх болон хэмжихдээ тэрхүү зах зээлийн нөхцлөөс доогуур нөхцлийг харгалзан үзэх эсэхэд нөлөө үзүүлэх учраас чухал ач холбогдолтой байдаг.

МЗУ86. Хөнгөлөлттэй зээл нь анхнаасаа зах зээлийн нөхцлөөс доогуур нөхцлөөр тухайн нөөцийг хүлээн авах эсвэл олгох явдал байдаг. Харин өрөөс чөлөөлөлт нь зах зээлтэй холбоотой нөхцлөөр анх олгосон буюу хүлээн авсан зээлийн үр дүн бөгөөд энд тухайн зээлийн оролцогч аль нэг тал нь анхны олголт эсвэл хүлээн авалтын хувьд өөрийн санаа төлөвлөгөөг дараагийн тайлант үед өөрчлөх явдал юм. Жишээлбэл; засгийн газар нь зах зээлийн нөхцлөөр зээлийг бүрэн буцаан төлүүлэх санаа төлөвлөгөөтэйгээр ашгийн төлөө бус байгууллагад мөнгө зээлдүүлж болох юм. Гэвч засгийн газар нь зээлийн тодорхой хэсгийг дараагийн тайлант үед хүчингүй болгож болно. Тухайн зээл нь анхнаасаа уг байгууллагад зах зээлийн түвшнээр зээл олгох явдал байсан учраас энэ нь хөнгөлөлттэй зээл биш юм. Байгууллага нь уг зээлийн дараагийн тайлант үеийн данснаас хасалтыг өрөөс чөлөөлөлт гэж үзэх бөгөөд УСНББОУС 29-ын үл хүлээн зөвшөөрөлтийн шаардлагуудыг мөрдөнө.

- МЗУ87. Хөнгөлөлттэй зээлийг зах зээлийн нөхцлөөс доогуур нөхцлөөр олгох буюу хүлээн авдаг учраас уг зээлийг анх хүлээн зөвшөөрөх үеийн ажил гүйлгээний үнэ нь түүний бодит үнэ биш байж болох юм. Иймээс анх хүлээн зөвшөөрөх үедээ байгууллага нь уг олгосон эсвэл хүлээн авсан зээлийн мөн чанарыг түүний бүрэлдэхүүн хэсгүүдээр задлан шинжлэх бөгөөд доорх МЗУ88, МЗУ89-р параграфт заасан зарчмуудыг ашиглан тэдгээр бүрэлдэхүүн хэсгүүдийг тайлагнадаг.
- МЗУ88. Байгууллага нь уг хөнгөлөлттэй зээл мөн чанарын хувьд үнэн хэрэгтэй зээл, буцалтгүй тусламж, эздийн хувь оролцоо эсвэл эдгээрийн хослол эсэхийг УСНББОУС 28 ба УСНББОУС 23-ын 42-58-р параграфт заасан зарчмуудыг мөрдсөнөөр юуны өмнө үнэлнэ. Ажил гүйлгээ эсвэл түүний нэг хэсэг нь зээл гэж уг байгууллага тодорхойлсон бол тэрхүү ажил гүйлгээний үнэ нь анх хүлээн зөвшөөрөх үед тухайн зээлийн бодит үнэ цэнийг төлөөлөн илэрхийлэх эсэхийг үнэлнэ. Байгууллага нь МЗУ101-МЗУ115-р параграфт заасан зарчмуудыг ашиглан уг зээлийн бодит үнэ цэнийг тодорхойлно. Байгууллага нь идэвхитэй зах зээлийг лавлагаа болгосноор бодит үнэ цэнийг тодорхойлж чадахгүй тохиолдолд үнэлгээний арга зүйг ашиглана. Ижил төсөвтэй зээлийн хүүний зах зээлийн түвшинг ашигласнаар ирээдүйн бүх мөнгөн орлогыг дискаунтчилж, үнэлгээний арга зүйгээр бодит үнэ цэнийг тодорхойлж болно (МЗУ82-р параграфыг үзнэ үү).
- МЗУ89. Зээлийн бодит үнэ цэнэ ба ажил гүйлгээний үнийн (зээлийн мөнгөн орлогын) хоорондох аливаа зөрүүг дараах байдлаар тайлагнана:
- (а) Байгууллага нь зээлийг хүлээн авсан тохиолдолд уг зөрүүг УСНББОУС 23-ын дагуу тайлагнана.
  - (б) Байгууллага нь зээл олгосон тохиолдолд уг зээл нь эзэд болохын хувьд тэдний бүрэн эрхийн хүрээнд эзэдтэй хийсэн ажил гүйлгээ байхаас бусад тохиолдолд тэрхүү зөрүүг анх хүлээн зөвшөөрөх үед ашиг, алдагдалд зардал гэж тайлагнана. Зээл нь эзэд болохын хувьд тэдний бүрэн эрхийн хүрээнд эзэдтэй хийсэн ажил гүйлгээ байх, тухайлбал, хяналт тавигч байгууллага нь хяналтанд буй байгууллагадаа хөнгөлөлттэй зээл олгох тохиолдолд уг зөрүү нь капиталын хувь оролцоог, өөрөөр хэлбэл зардал биш, харин байгууллагад оруулсан хөрөнгө оруулалтыг илэрхийлж болох юм.
- Үлгэрчилсэн жишээг УСНББОУС 23-ын ҮЖ54-р параграфт, түүнчлэн энэ Стандартыг дагалдах ҮЖ40, ҮЖ41-р параграфт харуулсан.
- МЗУ90. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, байгууллага нь 10-р параграфт тодорхойлсон, санхүүгийн хэрэглүүрийн ангиллуудыг ашигласнаар хөнгөлөлттэй зээлийг дараагийн тайлант үед хэмжинэ.

*Арилжааны бус орлогын ажил гүйлгээ*

МЗУ91. [Хасагдсан]

*Арилжааны бус ажил гүйлгээгээр гаргасан санхүүгийн баталгааг үнэлэх*

- МЗУ92. Зөвхөн гэрээний санхүүгийн баталгаа (буюу мөн чанарын хувьд гэрээ болох баталгаа) нь энэ Стандартын хүрээнд хамаарна (УСНББОУС 28-ын МЗУ3, МЗУ4-р параграфыг үзнэ үү). Гэрээний бус баталгаа нь санхүүгийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангахгүй учраас энэ Стандартын цар хүрээнд хамаарахгүй. Энэ Стандарт нь зөвхөн санхүүгийн баталгааны гэрээ гаргагчийн хувьд хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийн шаардлагуудыг тодорхойлдог.
- МЗУ93. “Санхүүгийн баталгааны гэрээ” гэдэг нь “өрийн хэрэглүүрийн анхны буюу засварлан өөрчилсөн нөхцлийн дагуу төлөх ёстой төлбөрөө тухайн зээлдэгч барагдуулаагүйн улмаас учирсан алдагдлын хувьд уг гэрээг эзэмшигчид нөхөн төлбөр болгон тодорхой төлбөр төлөхийг түүний гаргагчаас шаарддаг гэрээ юм” гэж 10-р параграфт тодорхойлсон байдаг. Бусад санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийн адилаар санхүүгийн баталгааны гэрээг энэхүү Стандартын шаардлагуудын дагуу анх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөхийг шаарддаг. Бодит үнэ цэнийг тодорхойлох талаархи тайлбар ба заавар удирдамжийг энэ Стандартын 50-52-р параграфт заасан бөгөөд МЗУ101-МЗУ115-р параграфт тусгасан Мөрдөх Заавар Удирдамж нь үүний гүйцээлт болно. Санхүүгийн баталгааны гэрээний дараагийн тайлант үеийн хэмжилт нь УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-ийн дагуу тодорхойлсон дүн ба анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс хэрэв хамааралтай бол УСНББОУС 9, *Арилжааны Ажил Гүйлгээний Орлого*-д заасан хуримтлагдсан хорогдуулгыг хассан дүнгийн аль өндөр нь байдаг.
- МЗУ94. Улсын секторын хувьд баталгааг ихэвчлэн арилжааны бус ажил гүйлгээний арга замаар, өөрөөр хэлбэл үнэгүй буюу нэрлэсэн төлбөртэйгээр гаргадаг. Байгууллагын эдийн засаг ба нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд энэ төрлийн баталгааг олгодог. Ийм зорилтуудад дэд бүтцийн төслүүдийг дэмжих, эдийн засгийн хямралын үед аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх, засгийн чиг үүрэг хэрэгжүүлэгч байгууллагуудын бонд гаргалтанд баталгаа гаргах, ажилтны хувьд өөрийн үүрэг, хариуцлагыг биелүүлэхдээ ашиглах автомашин худалдан авахад ажилтанд зээл олгох зэрэг ажиллагаа хамаарна. Санхүүгийн баталгаа төлбөртэй байх тохиолдолд байгууллага нь уг төлбөр арилжааны ажил гүйлгээнээс үүссэн эсэх, мөн төлбөр нь бодит үнэ цэнийг илэрхийлэх эсэхийг тодорхойлно. Хэрэв төлбөр нь бодит үнэ цэнийг илэрхийлэх бол байгууллага нь санхүүгийн баталгааг тэрхүү төлбөрийн дүнгээр хүлээн зөвшөөрнө. Дараагийн тайлант үеийн хэмжилт нь УСНББОУС 19-ийн дагуу тодорхойлсон дүн ба анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс хэрэв хамааралтай бол УСНББОУС 9-д заасан хуримтлагдсан хорогдуулгыг хассан дүнгийн аль өндөр нь байдаг. Байгууллага нь тухайн төлбөр бодит үнэ цэнэ биш гэж үзсэн тохиолдолд уг байгууллага нь ямар нэг төлбөр төлөөгүйтэй адилаар түүний дансны үнийг анх хүлээн зөвшөөрөх үед тодорхойлно.

- МЗУ95. Анх хүлээн зөвшөөрөх үед хураамж төлөөгүй эсвэл төлбөр нь бодит үнэ цэнэ биш байх тохиолдолд байгууллага нь тухайн байгуулсан гэрээтэй адилтгах санхүүгийн баталгааны гэрээний хувьд идэвхитэй зах зээлийн жишиг үнэ бэлэн боломжтой байгаа эсэхийг эхлээд харгалзан үздэг. Идэвхитэй зах зээлийн нотолгоонд зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хоорондох харилцан хамааралгүй талуудын сүүлийн үеийн ажил гүйлгээ ба гаргагч үнэгүй эсвэл нэрлэсэн төлбөртэйгээр нийлүүлдэг бараг ижил санхүүгийн баталгааны өөр бусад гэрээний одоогийн бодит үнэ цэнийн лавлагаа хамаарна. Зээлдэгч нь баталгаа гаргагчид төлбөр төлөхгүйгээр уг санхүүгийн баталгааны гэрээг байгуулж буй нь идэвхитэй зах зээл байхгүй гэсэн дүгнэлтийн шинжтэй нотолгоо дангаараа болохгүй юм. Худалдаа арилжааны зорилготой гаргагчаас баталгааг олж авах боломжтой боловч улсын секторын байгууллага нь худалдаа арилжааны бус олон учир шалтгааны улмаас санхүүгийн баталгааны гэрээ байгуулахыг зөвшөөрч болох юм. Жишээлбэл; зээлдэгч нь худалдаа арилжааны зорилготой хураамжийг төлөх боломжгүй бөгөөд тухайн байгууллагын нийгмийн буюу улс төрийн зорилтуудын нэгийг хэрэгжүүлэх төслийн санаачлага нь хэрэв санхүүгийн баталгаа гаргахгүй бол эрсдэлд орох тохиолдолд санхүүгийн баталгаа гаргуулахын тулд улсын секторын байгууллагад эсвэл засгийн газарт хандаж болох юм.
- МЗУ96. Шууд адилтгах баталгааны гэрээний идэвхитэй зах зээл байхгүй тохиолдолд байгууллага нь идэвхитэй зах зээлийн ажиглалтаас бусад үнэлгээний арга зүйг ашиглах боломжтой бөгөөд бодит үнэ цэнийн найдвартай хэмжилт хийж чадах эсэхийг харгалзан үзнэ. Ийм үнэлгээний арга зүй нь санхүүгийн эрсдлийг харгалзан үзсэн математик загвар тулгуурлаж болох юм. Жишээлбэл; “В” үндэсний засгийн газар нь “Х” хотын захиргааны бондын гаргалтанд баталгаа гаргадаг. “Х” хотын захиргаа нь өөрийн бондын гаргалтыг дэмжсэн засгийн газрын баталгаатай учраас түүний бонд нь засгийн газрын баталгаагаар дэмжэгдээгүй байх үеийнхээс арай бага купоны хүүтэй байна. Яагаад гэвэл, уг баталгаа нь хөрөнгө оруулагчдын хувьд бондын эрсдлийн хэмжээг бууруулах юм. Уг гаргалтыг засгийн газрын баталгаагаар дэмжээгүй бол тогтоогдох байсан купоны хүүний түвшин ба баталгаа бүхий купоны хүүний түвшин хоорондох зээлийн тархалтыг ашигласнаар тухайн баталгааны төлбөрийг тодорхойлж болно. Идэвхитэй зах зээлийн ажиглалтаар эсвэл үнэлгээний бусад арга зүйг ашигласнаар бодит үнэ цэнийг тодорхойлж болох тохиолдолд байгууллага нь уг санхүүгийн баталгааг санхүүгийн байдлын тайландаа бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх ба адилтгах дүн бүхий зардлыг санхүүгийн үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Идэвхитэй зах зээлийн ажиглалтанд тулгуурлаагүй үнэлгээний арга зүй ашиглах тохиолдолд байгууллага нь аливаа загварын гарц үр дүн найдвартай ба ойлгомжтой гэдэгт өөрөө итгэлтэй байх ёстой.
- МЗУ97. Идэвхитэй зах зээлийн ажиглалтаар эсвэл үнэлгээний бусад арга зүйг ашигласнаар бодит үнэ цэнийн найдвартай хэмжүүрийг тодорхойлж чадахгүй бол байгууллага нь уг санхүүгийн баталгааны гэрээг анх хүлээн

зөвшөөрөх үедээ УСНББОУС 19-ийн зарчмуудыг түүнд мөрдөх шаардлагатай. Санхүүгийн баталгааны гэрээтэй холбоотой өнгөрсөн үйл явдлын үр дүнд одоогийн үүрэг үүссэн эсэх, ийм одоогийн үүрэг нь тухайн гэрээний нөхцлүүдийн дагуу мөнгөн зарлага үүсгэх нилээд магадлалтай ба тэрхүү зарлагын талаар найдвартай тооцоолол хийж чадах эсэхийг байгууллага нь үнэлнэ. Тухайлбал; байгууллага нь маш олон тооны жижиг байгууллагуудад зээлийн баталгаа гаргах санхүүгийн баталгааны гэрээ байгуулдаг бөгөөд өнгөрсөн туршлагадаа үндэслэн тэдгээр байгууллагуудын тодорхой хэсэг нь зээлийг буцаан төлөхгүй гэдгийг мэддэг тохиолдолд санхүүгийн баталгааг анх хүлээн зөвшөөрөх үед түүнтэй холбоотойгоор одоогийн үүрэг үүсэх боломжтой юм.

*Санхүүгийн хөрөнгийн дараагийн тайлант үеийн хэмжилт (47 ба 48-р параграфууд)*

МЗУ98. Санхүүгийн хөрөнгө гэж өмнө нь хүлээн зөвшөөрч байсан санхүүгийн хэрэглүүрийг бодит үнэ цэнээр хэмждэг бөгөөд түүний бодит үнэ цэнэ нь тэг (0)-ээс бага болж, буурсан бол энэ нь 49-р параграфын дагуу хэмжих санхүүгийн өр төлбөр болох юм.

МЗУ99. Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгийн анхны болон дараагийн хэмжилтийн үеийн ажил гүйлгээний зардлыг хэрхэн тайлагнахыг дараах жишээнд үлгэрчлэн харуулав. Санхүүгийн хөрөнгийг 100ТН дээр 2ТН-ийн худалдааны шимтгэлийг нэмсэн дүнгээр худалдаж авсан. Уг хөрөнгийг анх 102ТН-ээр хүлээн зөвшөөрнө. Тухайн тайлант үе нь нэг өдрийн дараа дуусах бөгөөд энэ үед уг хөрөнгийн зах зээлийн жишиг үнэ нь 100ТН байсан. Хэрэв хөрөнгийг борлуулсан бол 3ТН-ийн шимтгэл төлөх байсан. Энэ өдөр тухайн хөрөнгийг 100ТН-ээр (борлуулахтай холбоотой боломжит шимтгэлийг харгалзан үзэхгүйгээр) хэмжиж, 2ТН-ийн гарзыг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө. Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө нь тогтмол буюу тодорхойлж болох төлбөрүүдтэй бол уг ажил гүйлгээний зардлыг үр ашигт хүүний арга ашиглан хорогдуулж, ашиг, алдагдалд тусгана. Хэрэв борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө нь тогтмол буюу тодорхойлж болох төлбөрүүдгүй бол уг ажил гүйлгээний зардлыг тухайн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрсөн эсвэл түүний үнэ цэнэ буурсан үед ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

МЗУ100. Зээл ба авлага гэж ангилсан хэрэглүүрийг тухайн байгууллага түүний дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших санаа төлөвлөгөөтэй эсэхийг үл харгалзан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ.

*Бодит үнэ цэнийн хэмжилтийн анхаарах зүйлс (50-52-р параграф)*

МЗУ101. Бодит үнэ цэнийн тодорхойлолтын суурь үндэслэл нь тухайн байгууллага татан буугдах, өөрийн үйл ажиллагааны цар хүрээг материаллаг хэмжээгээр багасгах эсвэл сөрөг нөхцлөөр ажил гүйлгээг хийх аливаа санаа төлөвлөгөөгүй буюу хэрэгцээ шаардлагагүй бөгөөд тасралтгүй байдлаар үйл ажиллагаагаа явуулна гэсэн урьдчилсан нөхцөл юм. Иймээс бодит үнэ цэнэ нь тухайн байгууллага албадан хүчилсэн ажил

гүйлгээ, сайн дурын бус татан буугдалт буюу дарамт шахалттай борлуулалтаар хүлээн авах эсвэл төлөх дүн биш юм. Гэхдээ бодит үнэ цэнэ нь тухайн хэрэглүүрийн зээлийн чанарыг тусгадаг.

МЗУ102. Энэ Стандарт нь жишиг зах зээлийн үнэтэй холбоотойгоор “санал болгосон худалдах үнэ”, “санал болгосон худалдан авах үнэ” (үүнийг зарим үед “одоогийн санал болгосон үнэ” гэж нэрлэдэг) гэсэн нэр томъёо, түүнчлэн зөвхөн ажил гүйлгээний зардлыг тусгахын тулд “санал болгосон худалдах-худалдан авах үнийн тархалт”<sup>14</sup> нэр томъёог ашигладаг. Бодит үнэ цэнийг тодорхойлохын тулд хийх бусад тохируулга (жишээлбэл; оролцогч нөгөө талын зээлийн эрсдлийн хувьд хийх тохируулга) нь “санал болгосон худалдах-худалдан авах үнийн тархалт” нэр томъёонд хамаарахгүй.

### **Идэвхитэй зах зээл: Жишиг үнэ**

МЗУ103. Хэрэв жишиг үнийг бирж, дилер, брокер, салбарын бүлэг, үнэ тогтоох үйлчилгээ, зохицуулалтын агентлагаас шууд, тогтмол авах боломжтой бөгөөд тэдгээр үнэ нь харилцан хамааралгүй талуудын сууриар бодитой ба тогтмол хийгдэх зах зээлийн ажил гүйлгээг төлөөлөн илэрхийлж байвал уг санхүүгийн хэрэглүүрийг идэвхитэй зах зээлийн жишиг үнэтэй гэж үзнэ. Арилжаанд оролцоход бэлэн байгаа худалдан авагч ба арилжаанд оролцоход бэлэн байгаа борлуулагч нар нь харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хүлээн зөвшөөрсөн үнийн нөхцлөөр бодит үнэ цэнийг тодорхойлдог. Идэвхитэй зах зээлд арилждаг санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тодорхойлох зорилго нь уг байгууллагын шууд хандан нэвтэрч болох хамгийн давуу талтай, идэвхитэй зах зээлд тэрхүү хэрэглүүрийг тухайн тайлант үеийн эцэст арилжих (өөрөөр хэлбэл, уг хэрэглүүрийг засварлан өөрчлөх буюу дахин нэгтгэн багцлахгүйгээр) ажил гүйлгээг хийх үнийг тогтоох явдал юм. Гэвч байгууллага нь тухайн зах зээлд арилжсан хэрэглүүрүүд болон уг үнэлж буй хэрэглүүрийн хоорондох оролцогч нөгөө талын зээлийн эрсдлийн аливаа зөрүүг тусгахын тулд тэрхүү илүү давуу талтай зах зээлийн үнийг тохируулдаг. Идэвхитэй зах зээлийн хэвлэн нийтэлсэн жишиг үнэ оршин байх нь бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо болох бөгөөд хэрэв ийм үнэ байгаа бол санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг хэмжихдээ түүнийг ашиглана.

МЗУ104. Эзэмшиж буй хөрөнгө буюу гаргах өр төлбөрийн хувьд зах зээлийн тохиромжтой жишиг үнэ нь ихэвчлэн одоогийн санал болгосон худалдан

---

<sup>14</sup> Bid-ask spread-Санал болгосон худалдах-худалдан авах үнийн тархалт. Bid нь “гуйх” гэсэн үгнээс үүсэлтэй бөгөөд санал өгөх үнэ юм. Өөрөөр хэлбэл, худалдан авагч нь тэдээр худалдаж авъя, авч болно гэж санал болгосон үнэ байдаг. Харин ask нь “асуух, шаардах” гэсэн үгнээс үүсэлтэй бөгөөд борлуулагч нь тэдээр худалдан ав гэж санал болгосон худалдан борлуулах үнийг илэрийлдэг. Энэхүү хоёр үнийн хоорондох зөрүүг тархалт гэж нэрлэдэг. Жишээлбэл; борлуулагч нь 100ТН-ээр борлуулах саналтай, худалдан авагч нь 80ТН-ээр худалдан авах саналтай бол тэдгээрийн хоорондох зөрүү 20ТН нь тархалт болно. Эндээс тархалтын муж нь 0-20ТН гэж үзэж болно. Түүнчлэн, 80ТН-ээс 100ТН-ийн хоорондох үнийг тархалтын муж доторх үнэ гэж бас хэлдэг. Ред.Ч.Д.



авах үнэ байдаг. Харин олж эзэмших хөрөнгө буюу хариуцаж буй өр төлбөрийн хувьд зах зээлийн тохиромжтой жишиг үнэ нь санал болгосон худалдах үнэ байна. Байгууллага нь харилцан суутгаж, цэвэр дүн гаргах зах зээлийн эрсдэл бүхий хөрөнгө ба өр төлбөртэй тохиолдолд харилцан суутгах эрсдлийн төлөв байдлын хувьд бодит үнэ цэнийг тогтоох суурь болгон зах зээлийн дундаж үнийг ашиглаж болох бөгөөд тэрхүү цэвэр төлөв байдалдаа уг санал болгосон худалдан авах үнэ эсвэл санал болгосон худалдах үнийн аль тохиромжтойг мөрдөнө. Санал болгосон худалдан авах үнэ ба санал болгосон худалдах үнэ бэлэн боломжтой байхгүй тохиолдолд хамгийн сүүлийн үеийн ажил гүйлгээний үнэ нь тэрхүү ажил гүйлгээний өдрөөс хойш эдийн засгийн нөхцөл байдалд мэдэгдэхүйц өөрчлөлт ороогүй бол уг одоогийн бодит үнэ цэнийн талаархи нотолгоогоор хангадаг. Хэрэв уг ажил гүйлгээ гарсан өдрөөс хойш нөхцөл байдал өөрчлөгдсөн (жишээлбэл; засгийн газрын бондын хамгийн сүүлийн үеийн жишиг үнийн дараах эрсдэлгүй хүүний түвшний өөрчлөлт) бол тухайн бодит үнэ цэнэ нь ижил төсөөтэй санхүүгийн хэрэглүүрүүдийн одоогийн үнэ буюу ханшийг зохих ёсоор харгалзсанаар тэрхүү нөхцөл байдлын өөрчлөлтийг тусгана. Үүнтэй адилаар, уг хамгийн сүүлийн ажил гүйлгээний үнэ нь бодит үнэ цэнэ биш гэдгийг тухайн байгууллага батлан харуулж чадах (жишээлбэл; энэ нь албадан хүчилсэн ажил гүйлгээ, сайн дурын бус татан буугдалт буюу дарамт шахалттай борлуулалтаар тухайн байгууллагын хүлээн авах эсвэл төлөх дүнг тусгадаг байх) бол тэрхүү үнийг тохируулна. Санхүүгийн хэрэглүүрийн багцын бодит үнэ цэнэ нь уг хэрэглүүрийн нэгжүүдийн тоо ба түүний жишиг зах зээлийн үнийн үржвэр байдаг. Бүхэлдээ тухайн санхүүгийн хэрэглүүрийн хувьд идэвхитэй зах зээлийн хэвлэн нийтэлсэн жишиг үнэ байхгүй боловч түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн жишиг үнэ байх тохиолдолд тэдгээр бүрэлдэхүүн хэсгүүдийн холбогдох зах зээлийн үнүүдэд үндэслэн бодит үнэ цэнийг тодорхойлно.

МЗУ105. Хэрэв идэвхитэй зах зээлд жишиг ханш (үнээс бусад) байгаа бол байгууллага нь бодит үнэ цэнийг тодорхойлох үнэлгээний арга зүйн орц болгон тэрхүү жишиг зах зээлийн ханшийг ашиглана. Хэрэв жишиг зах зээлийн ханш нь уг хэрэглүүрийн үнэ цэнийг тогтоохдоо зах зээлийн оролцогчдын харгалзан үздэг зээлийн эрсдэл буюу бусад хүчин зүйлсийг тусгаагүй бол тухайн байгууллага нь тэдгээр хүчин зүйлсийн хувьд тохируулга хийнэ.

#### **Идэвхитэй бус зах зээл: Үнэлгээний арга зүй**

МЗУ106. Санхүүгийн хэрэглүүрийн зах зээл нь идэвхитэй бус бол байгууллага нь үнэлгээний арга зүйг ашигласнаар бодит үнэ цэнийг тогтоодог. Зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хоорондох харилцан хамааралгүй зах зээлийн сүүлийн үеийн ажил гүйлгээ, хэрэв байгаа бол бараг ижил, бусад хэрэглүүрийн одоогийн бодит үнэ цэнийн лавлагаа, дискаунтчилсан мөнгөн гүйлгээний шинжилгээ, опционы үнэ тогтоох загвар ашиглалт нь үнэлгээний арга зүйд хамаардаг. Хэрэглүүрийн үнийг тогтоохын тулд зах зээлийн оролцогчдын нийтлэг ашигладаг үнэлгээний арга зүй байдаг бөгөөд уг арга зүй нь зах зээлийн

бодит ажил гүйлгээгээр олж авсан үнийн талаархи найдвартай тооцооллоор хангана гэдгийг харуулж байвал байгууллага нь тэрхүү арга зүйг ашиглана.

- МЗУ107. Үнэлгээний арга зүйг ашиглах зорилго нь хэвийн үйл ажиллагааны нөхцлөөр харилцан хамааралгүй талуудын хооронд хийгдэх ажил гүйлгээний үнийг уг хэмжилтийн өдрөөр тодорхойлох явдал байдаг. Зах зээлийн орцыг хамгийн ихээр ашиглах бөгөөд байгууллагын тусгайлсан орцод аль болох бага тулгуурлах үнэлгээний арга зүйн үр дүнд үндэслэн бодит үнэ цэнийг тооцоолдог. (а) Үнэлгээний арга зүй нь тухайн хэрэглүүрийн үнийг зах зээлээр хэрхэн тогтоох хүлээлтийг ул үндэслэлтэйгээр тусгадаг, ба (б) үнэлгээний арга зүйн орцууд нь зах зээлийн хүлээлт болон тухайн санхүүгийн хэрэглүүрийн угийн эрсдэл-өгөөжийн хүчин зүйлсийн хувьд хэмжилтийг ул үндэслэлтэйгээр илэрхийлдэг бол тэрхүү үнэлгээний арга зүйгээр бодит үнэ цэнийг бодитойгоор тооцоолно гэж үздэг.
- МЗУ108. Иймээс үнэлгээний арга зүй нь (а) зах зээлийн оролцогч нар үнэ тогтоохдоо харгалзах бүх хүчин зүйлсийг нэгтгэн тусгадаг, ба (б) санхүүгийн хэрэглүүрийн үнэ тогтоох эдийн засгийн хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалтай нийцдэг. Байгууллага нь үнэлгээний арга зүйг үечлэн шалгаж, тухайн хэрэглүүрийн ажиглаж болох одоогийн зах зээлийн аливаа ажил гүйлгээний үнийг (өөрөөр хэлбэл, засвар өөрчлөлт хийх буюу дахин нэгтгэн багцлахгүйгээр) ашигласнаар эсвэл ажиглаж болох зах зээлийн аливаа бэлэн боломжит мэдээнд үндэслэн түүний хүчин төгөлдөр байдлыг сорьж шалгадаг. Байгууллага нь тухайн хэрэглүүрийг анх үүсгэсэн буюу худалдан авсан зах зээл дэх зах зээлийн мэдээг тогтвортой олж авдаг. Тухайн хэрэглүүрийн ажиглаж болох одоогийн зах зээлийн бусад ажил гүйлгээтэй (өөрөөр хэлбэл, засвар өөрчлөлт хийх буюу дахин нэгтгэн багцлахгүйгээр) зэрэгцүүлснээр эсвэл хувьсагчид нь зөвхөн ажиглаж болох зах зээлийн мэдээг агуулсан үнэлгээний арга зүйд үндэслэн тэрхүү хэрэглүүрийн бодит үнэ цэнийг нотолдог байхаас бусад тохиолдолд арилжааны ажил гүйлгээний хувьд санхүүгийн хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо нь тухайн ажил гүйлгээний үнэ (өөрөөр хэлбэл, өгсөн эсвэл хүлээн авсан төлбөрийн бодит үнэ цэнэ) байдаг.
- МЗУ109. Санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийн дараагийн тайлант үеийн хэмжилт ба олз, гарзын дараагийн тайлант үеийн хүлээн зөвшөөрөлт нь энэ Стандартын шаардлагуудтай нийцсэн байна. МЗУ108-р параграфыг мөрдөх нь санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөх үед олз, гарз хүлээн зөвшөөрөхгүй байхад хүргэж болох юм. Ийм тохиолдолд УСНББОУС 29 нь үнэ тогтоохдоо тухайн зах зээлийн оролцогчдын харгалзан үзэх хүчин зүйлийн (үүн дотроо, цаг хугацааны) өөрчлөлтөөс үүссэн зөвхөн тэр хэмжээгээр олз, гарзыг анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа хүлээн зөвшөөрөхийг шаарддаг.
- МЗУ110. Санхүүгийн хөрөнгийн анх олж эзэмшилт буюу үүсгэн гаргалт эсвэл санхүүгийн өр төлбөрийн анх үүсгэн хариуцалт нь тухайн санхүүгийн

хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тооцоолох суурь үндэслэлийг бүрдүүлэх зах зээлийн ажил гүйлгээ юм. Тухайлбал; санхүүгийн хэрэглүүр нь өрийн хэрэглүүр (зээл гэх мэт) бол түүний олж эзэмшилт буюу үүсгэлтийн өдрөөр оршин байсан зах зээлийн нөхцөл байдал ба одоогийн зах зээлийн нөхцөл байдал эсвэл ижил төсөөтэй өрийн хэрэглүүрийн (өөрөөр хэлбэл, дуусгавар болох үлдсэн хугацаа, мөнгөн гүйлгээний хэв маяг, валют, зээлийн эрсдэл, барьцаа, хүүний суурийн хувьд ижил төсөөтэй) хувьд тухайн байгууллагын эсвэл бусад талуудын одоо тогтоосон хүүний түвшинг лавлагаа болгосноор уг өрийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тодорхойлдог. Нөгөө талаас, өрийн хэрэглүүрийг анх үүсгэсний дараах зээлдэгчийн зээлийн эрсдэл ба холбогдох зээлийн тархалтанд өөрчлөлт ороогүй бол уг суурь өрийн хэрэглүүрээс илүү сайн зээлийн чанартай бенчмарк хүүний түвшинг ашиглах, зээлийн тархалтыг тогтмол байлгах ба тэрхүү үүссэн өдрөөс хойш бенчмарк хүүний түвшинд орсон өөрчлөлтийн хувьд тохируулга хийснээр одоогийн зах зээлийн хүүний түвшний тооцооллыг хийж болно. Хамгийн сүүлийн үеийн зах зээлийн ажил гүйлгээнээс хойш нөхцөл байдал өөрчлөгдсөн бол уг үнэлж буй хэрэглүүрээс өөр байх аливаа ялгаатай талын хувьд зохих тохируулга хийсэн ижил төсөөтэй санхүүгийн хэрэглүүрийн одоогийн үнэ эсвэл ханшийг лавлагаа болгосноор тухайн үнэлж буй санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн харгалзах өөрчлөлтийг тодорхойлдог.

МЗУ111. Тухайн мэдээлэл нь хэмжилтийн өдөр бүр бэлэн боломжтой байхгүй байж болох юм. Жишээлбэл; байгууллага нь зээл олгох эсвэл идэвхитэй арилждаггүй өрийн хэрэглүүрийг олж эзэмшсэн өдөр тухайн байгууллага нь уг ажил гүйлгээний үнийг мэддэг бөгөөд энэ нь мөн зах зээлийн үнэ байна. Гэвч дараагийн хэмжилтийн өдөр шинэ ажил гүйлгээний мэдээлэл нь бэлэн боломжтой байхгүй байж болох бөгөөд хэдийгээр байгууллага нь зах зээлийн хүүний хувь хэмжээний ерөнхий түвшинг тодорхойлж чадах боловч тэрхүү өдрөөр уг хэрэглүүрийн үнийг тогтоохдоо зах зээлийн оролцогчдын харгалзан үзэх зээлийн буюу бусад эрсдлийн түвшинг мэдэхгүй байж болох юм. Байгууллага нь өнөөгийн үнэ цэнийн тооцооллд хамаарах дискаунтын хувь хэмжээг тодорхойлохдоо ашиглах хүүний суурь түвшинд харгалзах зохих зээлийн тархалтыг тодорхойлох сүүлийн үеийн ажил гүйлгээний мэдээлэлгүй байж болох юм. Эсрэг нотолгоо байхгүй тохиолдолд уг зээлийг олгох үед оршин байсан тархалтанд өөрчлөлт ороогүй гэж үзэх нь ул үндэслэлтэй юм. Гэвч ийм хүчин зүйлс өөрчлөгдсөн талаархи нотолгоо байгаа эсэхийг тодорхойлохын тулд байгууллага нь ул үндэслэлтэй хүчин чармайлтыг гаргана гэж үздэг. Өөрчлөлт гарсан талаархи нотолгоо байгаа тохиолдолд байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо уг өөрчлөлтийн үр нөлөөг харгалзан үзнэ.

МЗУ112. Дискаунтчилсан мөнгөн гүйлгээний шинжилгээг хэрэглэхдээ байгууллага нь тухайн хэрэглүүрийн зээлийн чанар, гэрээт хүүний хувь хэмжээ тогтмол байх үлдсэн хугацаа, үндсэн дүнг буцаан төлөх үлдсэн хугацаа, төлбөрийг барагдуулах валют зэргийн хувьд бараг ижил нөхцөл ба шинж чанар бүхий санхүүгийн хэрэглүүрүүдийн өгөөжийн давамгайлах түвшинтэй тэнцүү нэг буюу хэд хэдэн дискаунтын хувийг ашигладаг.

Хэрэв дискаунтын үр нөлөө нь материаллаг бус бол тогтоосон хүүгүй богино хугацаат авлага ба өглөгийг түүний анхны нэхэмжилсэн дүнгээр хэмжиж болно.

**Идэвхитэй бус зах зээл: Өмчийн хэрэглүүр**

МЗУ113. (а) Бодит үнэ цэнийн ул үндэслэлтэй тооцооллын муж доторх хувьсан өөрчлөлт нь тухайн хэрэглүүрийн хувьд мэдэгдэхүйц биш, эсвэл (б) тэрхүү мужийн хүрээн дэх янз бүрийн тооцооллуудын магадлалыг ул үндэслэлтэйгээр үнэлэх ба бодит үнэ цэнийг тооцоолохдоо түүнийг ашиглаж болох бол идэвхитэй зах зээлд жишиг зах зээлийн үнэгүй өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт, түүнчлэн ийм жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрийг нийлүүлснээр барагдуулах ёстой (48(в) ба 49-р параграфыг үзнэ үү) ба түүнтэй уялдсан үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжтой байдаг.

МЗУ114. Жишиг зах зээлийн үнэгүй өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт, түүнчлэн ийм жишиг үнэгүй өмчийн хэрэглүүрийг нийлүүлснээр барагдуулах ёстой (48(в) ба 49-р параграфыг үзнэ үү) ба түүнтэй уялдсан үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийн ул үндэслэлтэй тооцооллын муж доторх хувьсан өөрчлөлт нь мэдэгдэхүйц биш байх магадлалтай олон нөхцөл байдал байдаг. Байгууллага нь гаднын талуудаас олж эзэмшсэн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийг ихэвчлэн тооцоолох боломжтой байдаг. Гэвч бодит үнэ цэнийн ул үндэслэлтэй тооцооллын муж нь мэдэгдэхүйц бөгөөд янз бүрийн тооцооллын магадлалыг ул үндэслэлтэйгээр үнэлж чадахгүй бол байгууллага нь уг хэрэглүүрийг бодит үнэ цэнээр хэмжих боломжгүй юм.

**Үнэлгээний арга зүйн орцууд**

МЗУ115. Тодорхой санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тооцоолох тохиромжтой арга зүй нь зах зээлийн нөхцөл байдлын талаархи ажиглаж болох зах зээлийн мэдээ болон уг хэрэглүүрийн бодит үнэ цэнэд нөлөөлөх магадлалтай бусад хүчин зүйлсийг нэгтгэн тусгадаг. Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ нь дараах (магадгүй өөр бусад) нэг буюу хэд хэдэн хүчин зүйлсэд үндэслэдэг:

(а) Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ (өөрөөр хэлбэл, суурь эсвэл эрсдэлгүй хүүний түвшин). Суурь хүүний түвшинг засгийн газрын бондын ажиглаж болох үнээс ихэвчлэн тооцон гаргадаг бөгөөд санхүүгийн хэвлэлд байнга нийтэлдэг. Эдгээр түвшин нь цаг хугацааны янз бүрийн интервалд хамаарах хүүний түвшний өгөөжийн муруйн дагуу уг төсөвлөсөн мөнгөн гүйлгээний хүлээгдэж буй өдрүүдээр ихэвчлэн хувьсан өөрчлөгддөг. Практик шалтгааны улмаас байгууллага нь свопын ханш гэх мэт нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн, шууд ажиглаж болох зах зээлийн ерөнхий түвшинг бенчмарк түвшин болгон ашиглаж болох юм (Хэрэв ашигласан хувь хэмжээ нь эрсдэлгүй хүүний түвшин биш бол тухайн санхүүгийн хэрэглүүрт тохиромжтой зээлийн эрсдлийн тохируулгыг энэхүү

бенчмарк түвшинд хамаарах зээлийн эрсдэлтэй харьцуулсан түүний зээлийн эрсдэлд үндэслэн тодорхойлно). Зарим улс оронд төв засгийн газрын бонд нь зээлийн мэдэгдэхүйц эрсдэлтэй байж болох бөгөөд тухайн валютаар илэрхийлсэн хэрэглүүрийн хувьд тогтвортой бенчмарк суурь хүүний түвшин болж чадахгүй байж болох юм. Ийм улс оронд зарим байгууллагууд нь уг төв засгийн газраас илүү сайн зээлийн төлөв байдалтай бөгөөд зээллэгийн арай хүүтэй байж болно. Энэ тохиолдолд тухайн улсын валютаар гаргасан хамгийн өндөр зэрэглэлтэй, корпорацийн бондын хүүний түвшинг лавлагаа болгосноор суурь хүүний түвшинг илүү зохистой байдлаар тодорхойлж болох юм.

- (б) Зээлийн эрсдэл. Бодит үнэ цэнэд зээлийн эрсдлийн үзүүлэх үр нөлөөг (өөрөөр хэлбэл, зээлийн эрсдлийн хувьд суурь хүүний түвшин дээр нэмэгдэх урамшуулал) зээлийн янз бүрийн чанар бүхий, арилжаалсан хэрэглүүрүүдийн ажиглаж болох зах зээлийн үнээс эсвэл зээлийн өөр өөр зэрэглэл бүхий олгосон зээлийн хувьд зээлдүүлэгчийн тогтоосон, ажиглаж болох хүүний түвшнээс тооцон гаргаж болно.
- (в) Гадаад валютын ханш. Ихэнх гол валютын хувьд валютын арилжааны идэвхитэй зах зээл оршин байдаг бөгөөд санхүүгийн хэвлэлд ханшийг өдөр тутам жишиг болгон нийтэлдэг.
- (г) Бараа бүтээгдэхүүний үнэ. Маш олон бараа бүтээгдэхүүний хувьд ажиглаж болох зах зээлийн үнэ оршин байдаг.
- (д) Өмчийн үнэ. Арилжаалсан өмчийн хэрэглүүрийн үнийг (ба үнийн индексийг) зарим зах зээлд шууд ажиглах боломжтой байдаг. Ажиглаж болох үнэ байхгүй өмчийн хэрэглүүрийн одоогийн зах зээлийн үнийг тооцоолохын тулд өнөөгийн үнэ цэнийн арга зүйг ашиглаж болох юм.
- (е) Хувьсан өөрчлөлт (өөрөөр хэлбэл, санхүүгийн хэрэглүүр буюу бусад зүйлийн үнэд ирээдүйд гарах өөрчлөлтийн ач холбогдол). Идэвхитэй арилжаалдаг зүйлсийн хувьсан өөрчлөлтийн хэмжүүрийг зах зээлийн түүхэн мэдээнд үндэслэн эсвэл одоогийн зах зээлийн үнэд тусган илэрхийлэгдсэн хувьсан өөрчлөлтийг ашиглан ихэвчлэн ул үндэслэлтэйгээр тооцоолж болно.
- (ж) Урьдчилсан төлбөрийн эрсдэл ба төлбөр үл төлөх эрсдэл. Санхүүгийн хөрөнгийн хувьд хүлээгдэж буй урьдчилсан төлбөрийн хэв маяг ба санхүүгийн өр төлбөрийн хувьд хүлээгдэж буй төлбөр үл төлөх хэв маягийг түүхэн мэдээнд үндэслэн тооцоолж болно. (Нөгөө тал төлөхгүй байж болох санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнэ нь уг үл төлөх дүнгийн өнөөгийн үнэ цэнээс бага байж болохгүй - 52-р параграфыг үзнэ үү.)
- (и) Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрт үйлчилгээ үзүүлэх зардал. Зах зээлийн бусад оролцогчдын авах одоогийн хураамжтай хийсэн зэрэгцүүлэлтийг ашигласнаар үйлчилгээ үзүүлэх зардлыг тооцоолж болох юм. Хэрэв санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр

төлбөрт үйлчилгээ үзүүлэх зардал нь мэдэгдэхүйц хэмжээтэй бөгөөд зах зээлийн бусад оролцогчид нь зэрэгцүүлэгдэх зардал гаргадаг бол тэрхүү санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо гаргагч нь түүнийг харгалзан үзнэ. Ирээдүйн хураамж ба холбогдох зардал нь зах зээлийн зэрэгцүүлэгдэх дүнгүүдтэй нийцэхгүй байхаас бусад тохиолдолд ирээдүйн хураамжийг авах эрхийн уг гэрээ үүссэн өдрөөрх бодит үнэ цэнэ нь түүний хувьд төлсөн үүсгэлтийн зардалтай тэнцүү байх магадлалтай юм.

*Олз ба гарз (64-66-р параграф)*

МЗУ116. УСНББОУС 4-ийн дагуу мөнгөн зүйлс гэж үзэх бөгөөд гадаад валютаар илэрхийлэгдсэн, санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн хувьд байгууллага нь УСНББОУС 4-ийг мөрдөнө. Мөнгөн зүйлсийн хөрөнгө ба мөнгөн зүйлсийн өр төлбөрийн гадаад валютын ханшийн зөрүүгийн аливаа олз, гарзыг УСНББОУС 4-ийн дагуу ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Үүнд хамаарахгүй, гажих зүйлс нь мөнгөн гүйлгээний хейжид (106-112-р параграфыг үзнэ үү) эсвэл цэвэр хөрөнгө оруулалтын хейжид (113-р параграфыг үзнэ үү) хейжийн хэрэглүүр гэж сонгосон мөнгөн зүйлс юм. Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз, гарзыг УСНББОУС 4-ийн дагуу хүлээн зөвшөөрөх зорилгын хувьд, борлуулах боломжтой мөнгөн зүйлийн санхүүгийн хөрөнгийг тухайн гадаад валютаар илэрхийлсэн, хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө гэж үзнэ. Ингэснээр ийм санхүүгийн хөрөнгийн хувьд уг хорогдуулсан өртгийн өөрчлөлтөөс үүссэн ханшийн зөрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх ба дансны үнийн бусад өөрчлөлтийг 64(б) параграфын дагуу хүлээн зөвшөөрнө. УСНББОУС 4-ийн дагуу мөнгөн зүйлс болохгүй (жишээлбэл; өмчийн хэрэглүүр) борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгийн хувьд 64(б) параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн олз, гарзад аливаа холбогдох гадаад валютын ханшийн зөрүүгийн бүрэлдэхүүн хэсэг багтсан байдаг. Үүсмэл бус мөнгөн зүйлийн хөрөнгө ба үүсмэл бус мөнгөн зүйлийн өр төлбөрийн хооронд хейжийн харилцаа байгаа бол тэдгээр санхүүгийн хэрэглүүрүүдийн гадаад валютын бүрэлдэхүүн хэсгийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

*Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт ба үл цуглуулагдах байдал (67-79-р параграф)*

**Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн санхүүгийн хөрөнгө (72-74-р параграф)**

МЗУ117. Одоогийн зах зээлийн хүүний түвшнээр дискаунтчилах нь хорогдуулсан өртгөөр хэмжих байсан санхүүгийн хөрөнгийг үнэн хэрэгтээ бодит үнэ цэнээр хэмжсэнтэй адил нөлөө үзүүлэх учраас уг санхүүгийн хэрэглүүрийн анхны үр ашигт хүүний түвшинг ашигласнаар уг хорогдуулсан өртгөөр бүртгэсэн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг хэмжинэ. Зээл, авлага болон дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын нөхцлийг дахин хэлэлцэн тохирдог эсвэл

тухайн зээлдэгч буюу гаргагчийн санхүүгийн хүндрэлтэй байдлын улмаас нөхцлийг өөр бусад байдлаар хянан өөрчилдөг бол энэхүү нөхцлийн өөрчлөлтийн өмнө, уг анхны үр ашигт хүүний түвшинг ашигласнаар үнэ цэнийн бууралтыг хэмжинэ. Хэрэв дискаунтчлалын нөлөө нь материаллаг бус бол богино хугацаат авлагатай холбоотой мөнгөн гүйлгээг дискаунтчилахгүй. Хэрэв зээл, авлага болон дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт нь хувьсах хүүтэй бол 72-р параграфын дагуу аливаа үнэ цэнийн бууралтыг хэмжихэд зориулсан дискаунтын түвшин нь тухайн гэрээгээр тодорхойлох одоогийн үр ашигт хүүний түвшин байна. Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг практик арга туршлага болгон зээлдүүлэгч нь ажиглаж болох зах зээлийн үнийг ашигласнаар тухайн хэрэглүүрийн бодит үнэ цэнэд үндэслэн хэмжиж болох юм. Барьцаатай санхүүгийн хөрөнгийн ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийн тооцоолол нь барьцаа хөрөнгийг эзэмшилдээ авах магадлалтай эсэхээс үл хамааран, тухайн барьцаа хөрөнгөөс түүнийг олж эзэмших, борлуулах зардлыг хассаны дараах, хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний дүнг тусгадаг.

- MЗУ118. Үнэ цэнийн бууралтыг тооцоолох үйл явц нь зөвхөн чанар муутай зээлийн эрсдэл төдийгүй бүх зээлийн эрсдлийг харгалзан үздэг. Жишээлбэл; хэрэв байгууллага нь зээлийн зэрэглэл тогтоох дотоод системийг ашигладаг бол уг байгууллага нь зээлийн зөвхөн ноцтой доройтлыг төдийгүй бүх зээлийн зэрэглэлийг харгалзан үзнэ.
- MЗУ119. Үнэ цэнийн бууралтын гарзын дүнг тооцоолох үйл явц нь ганц дүнг эсвэл боломжит дүнгүүдийн мужийг гаргаж болох юм. Боломжит дүнгүүдийн мужийг тооцоолдог тохиолдолд байгууллага нь тухайн тайлант үеийн эцэст оршин буй бүх нөхцөл байдлын талаархи бэлэн боломжтой байгаа бүх холбогдох мэдээллийг тухайн санхүүгийн тайланг гаргахаас өмнө харгалзан үзсэнээр тэрхүү муж доторх хамгийн сайн тооцололтой тэнцүү дүнгээр үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрнө (боломжит үр дүнгүүдийн муж доторх хамгийн сайн тооцооллыг хэрхэн тодорхойлох талаархи заавар удирдамжийг УСНББОУС 19-ийн 47-р параграфт заасан).
- MЗУ120. Үнэ цэнийн бууралтын хамтын үнэлгээний зорилгын хувьд санхүүгийн хөрөнгүүдийг тэдгээрийн зээлийн эрсдлийн ижил төсөөтэй шинж чанаруудад (жишээлбэл; хөрөнгийн төрөл, салбар, газар зүйн байршил, барьцааны төрөл, хугацаа хэтрэлтийн төлөв байдал болон бусад холбогдох хүчин зүйлсийг харгалзсан зээлийн эрсдлийн үнэлгээний буюу зэрэглэл тогтоох үйл явцад) үндэслэн бүлэглэх бөгөөд энэ нь тухайн гэрээний нөхцлүүдийн дагуу төлөх ёстой бүх дүнгээ төлөх уг зээлдэгчийн чадвар боломжийн илэрхийлэл байна. Сонгон авсан шинж чанар нь уг үнэлж буй хөрөнгүүдийн гэрээний нөхцөлд заасан бүх дүнг төлөх зээлдэгчийн чадвар боломжоор илэрхийлэгдэх ийм хөрөнгүүдийн бүлгийн ирээдүйн мөнгөн гүйлгээний тооцоолол той холбоотой байна. Гэвч (а) үнэ цэнийн бууралтыг нь бие даасан байдлаар үнэлсэн бөгөөд үнэ цэнэ буураагүй гэж тогтоосон хөрөнгүүд, болон (б) үнэ цэнийн

бууралтыг нь бие даасан байдлаар үнэлээгүй бөгөөд үнэ цэнийн бууралтын өөр өөр дүнг шаардаж болох үр дүн бүхий хөрөнгүүд хоорондох бүлгийн түвшинд уг гарзын магадлал ба гарзын бусад статистик үзүүлэлтүүд нь ялгаатай байдаг. Хэрэв байгууллага нь ижил төсөөтэй эрсдлийн шинж чанар бүхий хөрөнгүүдийн бүлэггүй бол уг байгууллага нь ийм нэмэлт үнэлгээ хийхгүй.

МЗУ121. Бүлгийн сууриар хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарз нь үнэ цэнийн бууралтыг хамтад нь үнэлдэг санхүүгийн хөрөнгүүдийн бүлэгт багтсан бие даасан хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтын гарзыг тодорхойлохыг хүлээж буй завсрын алхамыг илэрхийлнэ. Бүлэгт багтсан бие даасан байдлаараа үнэ цэнэ буурсан хөрөнгүүдийн хувьд гарзыг тусгайлан тогтоох мэдээлэл бэлэн олдцотой болмогц тэдгээр хөрөнгүүдийг тухайн бүлгээс хасна.

МЗУ122. Үнэ цэнийн бууралтыг хамтад нь үнэлдэг санхүүгийн хөрөнгүүдийн бүлгийн ирээдүйн мөнгөн гүйлгээг тухайн бүлэгт багтсан хөрөнгүүдтэй ижил төсөөтэй зээлийн эрсдлийн шинж чанар бүхий хөрөнгүүдийн гарзын түүхэн туршлагад үндэслэн тооцоолно. Байгууллагын тусгайлсан гарзын туршлагагүй буюу хангалттай бус туршлагатай байгууллагууд нь уг адилтган зэрэгцүүлэгдэх санхүүгийн хөрөнгүүдийн бүлгийн хувьд ижил төсөөтэй бүлгийн туршлагыг ашиглана. Гэвч уг түүхэн мэдээний үндэслэл болох тэрхүү тайлант үед хамааралгүй одоогийн нөхцөл байдлын үр нөлөөг тусгах ба ирээдүйн гэрээний мөнгөн гүйлгээнд хамааралгүй тухайн түүхэн тайлант үеийн нөхцөл байдлуудын нөлөөг арилгахын тулд одоогийн ажиглаж болох мэдээнд үндэслэн зээлийн алдагдлын туршлага гэх мэт түүхэн мэдээг засварлан тохируулна. Ирээдүйн мөнгөн гүйлгээний өөрчлөлтийн тооцоолол нь нэг тайлант үеэс нөгөө тайлант үед уг ажиглаж болох холбогдох мэдээнд гарсан өөрчлөлтийг (жишээлбэл; ажилгүйдлийн түвшин, үл хөдлөх хөрөнгийн үнэ, бараа бүтээгдэхүүний үнэ, төлбөрийн статус, түүнчлэн тухайн санхүүгийн хэрэглүүрүүдийн бүлгийн зээлийн алдагдлыг илтгэх бусад хүчин зүйлсийн өөрчлөлт болон тэдгээр өөрчлөлтийн ач холбогдол) тусгах бөгөөд чиглэлийн хувьд түүнтэй нийцсэн байвал зохино. Гарзын тооцоолол ба гарзын бодит туршлагын хоорондох аливаа зөрүүг багасгахын тулд ирээдүйн мөнгөн гүйлгээг тооцоолохдоо ашигласан арга зүй, таамаглалыг тогтмол нягталж шалгана.

МЗУ123 МЗУ122-р параграфыг мөрдөх жишээ болгон байгууллага нь зээлдэгч төлбөрөө төлөхгүй байх нэг үндсэн шалтгаан бол тухайн зээлдэгчийн нас баралт гэдгийг өөрийн түүхэн туршлагадаа үндэслэн тодорхойлж болно. Нас баралтын түвшин нь нэг жилээс дараагийн жилд өөрчлөгдөөгүй гэдгийг уг байгууллага нь ажиглаж болох юм. Хэдийгээр уг байгууллагын зээлийн багц дахь зарим зээлдэгч нь тухайн жилд нас барж, ингэснээр тэдгээр зээлийн хувьд үнэ цэнийн бууралтын гарз үүссэн гэдгийг тэрхүү жилийн эцэст илэрхийлж болох боловч байгууллага нь чухам аль зээлдэгч нас барсныг хараахан мэдээгүй байдаг. “Гарч тохиолдсон боловч тайлагнаагүй” гарзын хувьд үнэ цэнийн бууралтын гарз хүлээн зөвшөөрөх нь тохиромжтой юм. Гэвч шаардлагатай гарзын үйл явдал



(зээлдэгчийн нас баралт) хараахан гарч тохиолдоогүй байгаа учраас ирээдүйн тайлант үед гарч тохиолдохоор хүлээгдэж буй нас баралтын хувьд үнэ цэнийн бууралтын гарз хүлээн зөвшөөрөх нь тохиромжгүй байдаг.

МЗУ124. Ирээдүйн мөнгөн гүйлгээг тооцоолохдоо гарзын түүхэн туршлагын хувь хэмжээг ашиглах бол тухайн түүхэн гарзын хувь хэмжээг ажиглан гаргасан бүлгүүдтэй нийцэх тийм арга замаар тодорхойлсон бүлгүүдийн хувьд тэрхүү гарзын түүхэн хувь хэмжээний талаархи мэдээллийг хэрэглэх нь чухал ач холбогдолтой юм. Ингэснээр уг ашигласан арга зүй нь ижил төсөөтэй эрсдлийн шинж чанар ба одоогийн нөхцөл байдлыг тусгасан, ажиглаж болох холбогдох мэдээ бүхий санхүүгийн хөрөнгүүдийн бүлгийн гарзын өмнөх туршлагын талаархи мэдээлэлтэй тухайн санхүүгийн хөрөнгүүдийн бүлэг нэг бүрийг харгалзуулан холбох боломжийг олгодог.

МЗУ125. Томъёонд үндэслэсэн хандлага буюу статистик арга нь 72-74-р параграфт болон МЗУ120-МЗУ124-р параграфт заасан шаардлагуудтай нийцэх тохиолдолд санхүүгийн хөрөнгүүдийн бүлгийн (жишээлбэл; бага үлдэгдэлтэй зээлүүдийн) үнэ цэнийн бууралтын гарзыг тодорхойлохдоо тэдгээр хандлага буюу аргыг ашиглаж болох юм. Ашигласан аливаа загвар нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн үр нөлөөг тусгаж, хөрөнгийн ашиглалтын (зөвхөн дараагийн жил төдийгүй) үлдсэн бүх хугацааны мөнгөн гүйлгээг илэрхийлэх ба тухайн багцын доторх зээлийн насжилтыг харгалзах боловч санхүүгийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үед үнэ цэнийн бууралтын гарз үүсгэхээргүй байна.

### **Үнэ цэнийн бууралтын хүлээн зөвшөөрөлтийн дараах хүүний орлого**

МЗУ126. Үнэ цэнийн бууралтын гарзын үр дүнд санхүүгийн хөрөнгө буюу ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгүүдийн бүлгийн үнэ цэнийг бууруулмагц уг үнэ цэнийн бууралтын гарзыг хэмжих зорилгоор ирээдүйн мөнгөн гүйлгээг дискаунтчлахдаа ашигласан хүүний түвшинд үндэслэн үүнээс хойшхи хүүний орлогыг хүлээн зөвшөөрнө.

### **Хейж (80-113-р параграф)**

*Хейжийн хэрэглүүр (81-86-р параграф)*

#### **Шалгуур хангах хейжийн хэрэглүүр (81 ба 82-р параграф)**

МЗУ127. Байгууллагын гаргасан опционы боломжит гарз нь холбогдох хейжийн зүйлийн үнэ цэнийн боломжит олзоос мэдэгдэхүйц их байж болох юм. Өөрөөр хэлбэл, гаргасан опцион нь хейжийн зүйлийн ашиг, алдагдлын эрсдлийг бууруулахад үр дүнгүй байна. Иймээс гаргасан опцион нь худалдан авсан опционы нөхөлт гэж сонгогдсон, түүнчлэн энэ нь бусад санхүүгийн хэрэглүүрийг дагалдахаас (жишээлбэл; дуудах боломжтой өр төлбөрт хейж хийхийн тулд ашигладаг гаргасан дуудах опцион) бусад тохиолдолд уг гаргасан опцион нь хейжийн хэрэглүүрийн шалгуурыг

хангахгүй. Харин эсрэгээр, худалдан авсан опцион нь гарзтай тэнцүү эсвэл түүнээс илүү байх боломжит олзтой, иймээс бодит үнэ цэнийн буюу мөнгөн гүйлгээний өөрчлөлтийн улмаас ашиг, алдагдлыг бууруулах боломжтой байдаг. Иймээс энэ нь хейжийн хэрэглүүрийн шалгуурыг хангана.

МЗУ128. Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн, дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтыг гадаад валютын эрсдлийн хейжийн хувьд хейжийн хэрэглүүр гэж сонгож болно.

МЗУ129. Бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжиж чадахгүйн улмаас бодит үнэ цэнээр бүртгэдэггүй, жишиг зах зээлийн үнэгүй өмчийн хэрэглүүрт эсвэл ийм жишиг зах зээлийн үнэгүй өмчийн хэрэглүүртэй уялдсан ба түүнийг өгснөөр барагдуулах ёстой үүсмэл хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтыг (48(в) ба 49-р параграфыг үзнэ үү) хейжийн хэрэглүүр гэж сонгож болохгүй.

МЗУ130. Байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүр нь уг байгууллагын санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр биш, иймээс түүнийг хейжийн хэрэглүүр гэж сонгож болохгүй.

*Хейжийн зүйлс (87-94-р параграф)*

#### **Шалгуур хангах хейжийн зүйлс (87-89-р параграф)**

МЗУ131. Хейж хийгдэж буй бусад эрсдлүүдийг тусгайлан тодорхойлж, хэмжих боломжгүй учраас улсын секторын нэгдлээр байгууллага буюу нэгдмэл цогц үйл ажиллагааг худалдан авах арилжааны баталгаа нь гадаад валютын ханшийн эрсдлээс бусад эрсдлийн хувьд хейжийн зүйл болж чадахгүй. Тэдгээр бусад эрсдэл нь ерөнхий үйл ажиллагааны эрсдэл юм.

МЗУ132. Өмчийн арга нь хараат байгууллагын ашиг, алдагдал дахь тухайн хөрөнгө оруулагчийн хувь оролцоог уг хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлт биш, харин ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг тул өмчийн аргаар бүртгэсэн хөрөнгө оруулалт нь бодит үнэ цэнийн хейж дэх хейжийн зүйл болж чадахгүй. Үүнтэй адил шалтгаанаар, нэгтгэл нь хяналтанд буй байгууллагын ашиг, алдагдлыг уг хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлт биш, харин ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг тул нэгтгэсэн хяналтанд буй байгууллага дахь хөрөнгө оруулалт нь бодит үнэ цэнийн хейжийн хувьд хейжийн зүйл болж чадахгүй. Гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хейж нь уг хөрөнгө оруулалтын үнэ цэнэд гарсан өөрчлөлтийн бодит үнэ цэнийн хейж биш, харин гадаад валютын эрсдлийн хейж учраас үүнээс өөр байдаг.

МЗУ133. Эдийн засгийн нэгдмэл байгууллага доторх, хэрэгжих өндөр магадлалтай урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь тухайн ажил гүйлгээг хийж буй байгууллагын бүртгэлийн валютаас өөр валютаар илэрхийлэгдсэн бөгөөд түүний гадаад валютын эрсдэл нь нэгтгэсэн ашиг, алдагдалд нөлөөлдөг бол уг ажил гүйлгээний гадаад валютын эрсдэл нь нэгтгэсэн

санхүүгийн тайлангийн хувьд хейжийн зүйлийн шалгуурыг хангаж болно гэдгийг 89-р параграфт заасан байдаг. Энэ зорилгын хувьд байгууллага нь хяналт тавигч байгууллага, хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр эсвэл салбар байж болно. Хэрэв эдийн засгийн нэгдмэл байгууллагын доторх, урьдчилан таамагласан ажил гүйлгээний гадаад валютын эрсдэл нь нэгтгэсэн ашиг, алдагдалд нөлөөлдөггүй бол уг ажил гүйлгээ нь хейжийн зүйлийн шалгуурыг хангахгүй юм. Холбогдох гаднын ажил гүйлгээ байхгүй бол эрхийн шимтгэлийн төлбөр, хүүний төлбөр, тухайн нэг эдийн засгийн нэгдмэл байгууллагын гишүүдийн хоорондох менежментийн төлбөрийн хувьд ихэвчлэн ийм тохиолдол үүсдэг. Гэвч эдийн засгийн нэгдмэл байгууллагын доторх урьдчилан таамагласан ажил гүйлгээний гадаад валютын эрсдэл нь нэгтгэсэн ашиг, алдагдалд нөлөөлдөг тохиолдолд уг ажил гүйлгээ нь хейжийн зүйлийн шалгуурыг хангана. Жишээ нь; эдийн засгийн нэгдмэл байгууллагын хувьд гадны байх этгээдэд тухайн бараа материалыг өмнө нь борлуулж байсан бол уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын гишүүдийн хоорондох бараа материалын урьдчилан таамагласан борлуулалт эсвэл худалдан авалт. Үүнтэй адилаар, үндсэн хөрөнгийг өөрийн үйл ажиллагаандаа ашиглах эдийн засгийн нэгдмэл байгууллагын нэг байгууллагад уг үндсэн хөрөнгийг үйлдвэрлэдэг тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын өөр нэг байгууллагаас хийх, урьдчилан таамагласан хоорондын борлуулалт нь нэгтгэсэн ашиг, алдагдалд нөлөөлж болох юм. Жишээлбэл; эдийн засгийн нэгдмэл байгууллагын доторх урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь тухайн худалдан авч буй байгууллагын бүртгэлийн валютаас өөр валютаар илэрхийлэгдсэн бол уг үндсэн хөрөнгийн хувьд анх хүлээн зөвшөөрсөн дүн нь өөрчлөгдөж болох бөгөөд тэрхүү худалдан авч буй байгууллага нь үндсэн хөрөнгийг элэгдүүлэх тул ийм тохиолдол үүсэж болно.

МЗУ134. Эдийн засгийн нэгдмэл байгууллагын доторх урьдчилан таамагласан ажил гүйлгээний хейж нь хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангадаг бол 10б(а) параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн аливаа олз, гарзыг уг хейж хийсэн ажил гүйлгээний гадаад валютын эрсдэл нь нэгтгэсэн ашиг, алдагдалд нөлөө үзүүлэх тэрхүү тайлант үед буюу үеүдэд ашиг, алдагдалд дахин ангилна.

МЗУ135. Байгууллага нь хейжийн зүйлийн мөнгөн гүйлгээний буюу бодит үнэ цэнийн бүх өөрчлөлтийг хейжийн харилцаанд сонгож болно. Байгууллага нь хейжийн зүйлийн зөвхөн мөнгөн гүйлгээний эсвэл зөвхөн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тодорхой үнэ буюу бусад хувьсагчаас илүү эсвэл бага байхаар (нэг талт эрсдэл) бас сонгож болох юм. Хейжийн хэрэглүүр болгон худалдан авсан опционы (сонгосон эрсдэлтэй үүнийг ижил үндсэн нөхцөлтэй гэж үзэх) цаг хугацааны үнэ цэнэ биш, харин дотоод үнэ цэнэ нь хейжийн зүйл дэх нэг талт эрсдлийг тусгадаг. Жишээлбэл; байгууллага нь барааны урьдчилан таамагласан худалдан авалтын үнийн өсөлтөөс бий болох ирээдүйн мөнгөн зарлагын өөрчлөлтийг сонгож болно. Энэ тохиолдолд тогтоосон түвшнээс давсан үнийн өсөлтийн үр дүн болох зөвхөн мөнгөн гүйлгээний алдагдлыг сонгоно. Цаг хугацааны үнэ цэнэ нь ашиг, алдагдалд нөлөөлөх уг урьдчилан таамагласан ажил гүйлгээний

бүрэлдэхүүн хэсэг биш учраас тэрхүү хейж хийсэн эрсдэл нь тухайн худалдан авсан опционы цаг хугацааны үнэ цэнийг өөртөө агуулаагүй байдаг (96(б) параграф).

**Санхүүгийн зүйлсийг хейжийн зүйлс гэж сонгох (90, 91-р параграф)**

МЗУ136. Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн мөнгөн гүйлгээний нэг хэсгийг хейжийн зүйл гэж сонгосон бол тэрхүү сонгосон хэсэг нь тухайн хөрөнгө буюу өр төлбөрийн нийт мөнгөн гүйлгээнээс бага байх ёстой. Жишээлбэл; зах зээлийн холбогдох хүүний түвшнээс бага үр ашигт хүү бүхий өр төлбөрийн хувьд байгууллага нь (а) өр төлбөрийн тэрхүү хэсэг нь үндсэн дүн дээр зах зээлийн холбогдох хүүг нэмсэнтэй тэнцүү ба (б) үлдэх хэсэг нь сөрөг дүнтэй гэж сонгож болохгүй. Гэхдээ байгууллага нь тухайн нийт санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн бүх мөнгөн гүйлгээг хейжийн зүйл гэж сонгох ба зөвхөн тодорхой нэг эрсдлийн (жишээлбэл; зах зээлийн хүүний түвшний өөрчлөлтөнд хамааруулж болох зөвхөн тэрхүү өөрчлөлтийн) хувьд тэдгээрт хейж хийж болно. Жишээлбэл; зах зээлийн хүүнээс 100 суурь нэгжээр бага, үр ашигт хүү бүхий санхүүгийн өр төлбөрийн хувьд байгууллага нь тухайн нийт өр төлбөрийг (өөрөөр хэлбэл, үндсэн дүн дээр зах зээлийн түвшнээр тооцсон хүүг нэмж, 100 суурь нэгжийг хассан дүнг) хейжийн зүйл гэж сонгох ба зах зээлийн хүүний түвшний өөрчлөлтөнд хамааруулж болох уг нийт өр төлбөрийн бодит үнэ цэнийн эсвэл мөнгөн гүйлгээний өөрчлөлтөнд хейж хийж болно. Байгууллага нь МЗУ140-р параграфт тайлбарласанчлан, хейжийн үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэхийн тулд нэг-нэг гэсэн харьцаанаас өөр хейжийн харьцааг бас сонгож болно.

МЗУ137. Мөн түүнчлэн, тогтмол хүүний түвшинтэй санхүүгийн хэрэглүүрт түүнийг үүссэнээс хойш тодорхой хугацааны дараа хейж хийсэн ба энэ хугацаанд хүүний түвшнүүд өөрчлөгдсөн бол байгууллага нь тухайн хэрэглүүрт гэрээний дагуу төлсөн хүүний түвшнээс өндөр байх бенчмарк түвшинтэй тэнцүү хэсэгт хейж хийхээр сонгож болно. Байгууллага нь уг хейжийн зүйлийг анх сонгосон өдрөөр тэрхүү хэрэглүүрийг худалдан авсан бол дэвшүүлэх байсан таамаглалд үндэслэж, тооцоолсон үр ашигт хүүний түвшнээс бенчмарк түвшин нь бага байвал тухайн байгууллага нь ингэж хейж хийж болох юм. Жишээлбэл; зах зээлийн хүү 4 хувь байх үед байгууллага нь 6 хувийн үр ашигт хүүтэй, тогтмол хүүний түвшин бүхий 100ТН-ийн санхүүгийн хөрөнгөтэй байна гэж үзье. Хэсэг хугацааны дараа зах зээлийн хүү нь 8 хувь болж өссөн ба хөрөнгийн бодит үнэ цэнэ нь 90ТН хүртэл буурсан үед тухайн хөрөнгөнд хейж хийж эхэлсэн. Байгууллага нь уг хөрөнгийг хейжийн зүйл гэж анх сонгосон өдрөөр түүнийг худалдан авсан бол бодит үнэ цэнийг 90ТН, үр ашигт өгөөжийг 9.5 гэж тооцоолох байсан. Зах зээлийн хүү нь энэхүү үр ашигт өгөөжөөс бага байгаа тул байгууллага нь 8 хувийн зах зээлийн хүүг сонгож болох юм. Энэхүү 8 хувийн зах зээлийн хүү нь нэг талаас, гэрээнд заасан хүүний мөнгөн гүйлгээ, нөгөө талаас хөрөнгийн одоогийн бодит үнэ цэнэ (өөрөөр хэлбэл, 90ТН) ба дуусгавар болох үед буцаан төлөх дүнгийн (өөрөөр хэлбэл, 100ТН) хоорондох зөрүүгээс бүрдэнэ.

МЗУ138. Байгууллага нь санхүүгийн хэрэглүүрийн нийт бодит үнэ цэнийн өөрчлөлт эсвэл нийт мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлтөөс бусад тодорхой нэг хэсгийг сонгохыг 90-р параграфтаар зөвшөөрсөн байдаг. Тухайлбал:

- (а) Зарим эрсдэлд (гэхдээ бүх эрсдэлд биш) хамааруулж болох мөнгөн гүйлгээний буюу бодит үнэ цэнийн өөрчлөлтүүдийн хувьд санхүүгийн хэрэглүүрийн бүх мөнгөн гүйлгээг сонгож болно; эсвэл
- (б) Бүх эсвэл зөвхөн зарим эрсдэлд хамааруулж болох мөнгөн гүйлгээний буюу бодит үнэ цэнийн өөрчлөлтүүдийн хувьд санхүүгийн хэрэглүүрийн зарим (гэхдээ бүх биш) мөнгөн гүйлгээг сонгож болно (өөрөөр хэлбэл, бүх эсвэл зөвхөн зарим эрсдэлд хамааруулж болох өөрчлөлтүүдийн хувьд тухайн санхүүгийн хэрэглүүрийн мөнгөн гүйлгээний “хэсэг”-ийг сонгож болох юм).

МЗУ139. Хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангахын тулд, тухайн сонгосон эрсдлүүд болон тэдгээрийн хэсгүүд нь санхүүгийн хэрэглүүрийн тусдаа тодорхойлж болох бүрэлдэхүүн хэсгүүд байх ёстой бөгөөд уг сонгосон эрсдлүүд ба тэдгээрийн хэсгүүдийн өөрчлөлтөөс бий болсон, тэрхүү нийт санхүүгийн хэрэглүүрийн мөнгөн гүйлгээний буюу бодит үнэ цэнийн өөрчлөлтийг найдвартай хэмжих боломжтой байх ёстой. Жишээлбэл:

- (а) Эрсдэлгүй эсвэл бенчмарк хүүний түвшний өөрчлөлтөнд хамаарах бодит үнэ цэнийн өөрчлөлтөнд хейж хийсэн, тогтмол хүүний түвшин бүхий санхүүгийн хэрэглүүрийн хувьд уг эрсдэлгүй эсвэл бенчмарк хүүний түвшинг ихэвчлэн тухайн санхүүгийн хэрэглүүрийн тусдаа тодорхойлж, найдвартай хэмжиж болох бүрэлдэхүүн хэсэг гэж үздэг.
- (б) (в) заалт дахь шаардлагууд хангагдахаас бусад тохиолдолд инфляцийг тусдаа тодорхойлж, найдвартай хэмжих боломжгүй бөгөөд санхүүгийн хэрэглүүрийн эрсдэл эсвэл эрсдлийн хэсэг гэж тодорхойлж болохгүй.
- (в) Хэрэглүүрийн бусад мөнгөн гүйлгээнд инфляцийн хэсэг нөлөө үзүүлэхгүй байх тохиолдолд хүлээн зөвшөөрсөн, инфляцитай уялдаатай бондын мөнгөн гүйлгээнээс гэрээгээр тусгайлан заасан инфляцийн хэсгийг (дагалдах үүсмэл хэрэглүүрийг тусдаа тайлагнах шаардлагагүй гэж үзнэ) тусдаа тодорхойлж, найдвартай хэмжих боломжтой байдаг.

**Санхүүгийн бус зүйлсийг хейжийн зүйлс гэж сонгох (92-р параграф)**

МЗУ140. Санхүүгийн бус хөрөнгө, санхүүгийн бус өр төлбөрийн орц буюу бүрэлдэхүүн хэсгийн үнийн өөрчлөлт нь түүний үнэтэй зэрэгцүүлэгдэх боломжтой бөгөөд урьдчилан таамаглаж, тусдаа хэмжиж болох тийм зүйлсгүй байдаг. Харин санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр, тухайлбал; бондын хувьд түүний үнэд нь зах зээлийн хүүний түвшний өөрчлөлт нөлөө үзүүлдэг. Иймээс санхүүгийн бус хөрөнгө, санхүүгийн бус өр төлбөр нь зөвхөн бүхэлдээ, эсвэл зөвхөн гадаад валютын ханшийн

эрсдлийн хувьд хейжийн зүйл болно. Хейжийн хэрэглүүр ба хейжийн зүйлийн нөхцлүүд хоорондоо ялгаатай (жишээлбэл; ижил нөхцлөөр “Свийт”<sup>15</sup> шингэн түүхий газрын тос худалдан авах форвард гэрээг ашиглаж, Brent<sup>16</sup> түүхий газрын тосны урьдчилан таамагласан худалдан авалтын хувьд хейж хийх гэх мэт) байх үед 98-р параграфт заасан бүх нөхцлүүд хангагдсан, үүн дотроо тухайн хейжийг өндөр үр дүнтэй гэж хүлээж байх тохиолдолд уг хейжийн харилцаа нь ямартаа ч хейжийн харилцаа болох шалгуурыг хангаж чадах юм. Энэхүү зорилгын хувьд хэрэв хейжийн харилцааны үр дүнтэй байдлыг сайжруулж байвал хейжийн хэрэглүүрийн дүн нь хейжийн зүйлийн дүнгээс их эсвэл бага байж болно. Тухайлбал; хейжийн зүйл (жишээ нь: Brent газрын тосны арилжаа) ба хейжийн хэрэглүүрийн (жишээ нь: Свийт газрын тосны арилжаа) хоорондох статистик харилцан хамаарлыг тогтоохын тулд регрессийн шинжилгээ хийж болно. Хэрэв хоёр хувьсагчдын хооронд (өөрөөр хэлбэл, Brent ба Свийт газрын тосны нэгжийн үнийн хооронд) хүчин төгөлдөр статистик хамаарал байвал хүлээгдэж буй үр дүнтэй байдлыг хамгийн их болгох хейжийн харьцааг тогтоохын тулд регрессийн шугамын өнцгийн коэффициентийг ашиглаж болно. Жишээлбэл; регрессийн шугамын өнцгийн коэффициент нь 1.02 бол 0.98 тоо хэмжээ бүхий хейжийн зүйлд 1.00 тоо хэмжээ бүхий хейжийн хэрэглүүр байх хейжийн харьцаа нь хүлээгдэж буй үр дүнтэй байдлыг хамгийн их болгох юм. Гэвч хейжийн харилцаа нь үр дүнгүй байдалд хүргэж болох бөгөөд үүнийг тухайн хейжийн харилцааны хугацаанд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

### **Зүйлсийн бүлгүүдийг хейжийн зүйлс гэж сонгох (93, 94-р параграф)**

МЗУ141. Тухайн нэг хейжийн зүйлийн биш, харин ерөнхий цэвэр дүнгийн (жишээлбэл; ижил дуусгавар хугацаа бүхий тогтмол хүүтэй бүх хөрөнгө ба тогтмол хүүтэй бүх өр төлбөрийн цэвэр дүнгийн) хейж нь хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангадаггүй. Гэвч тухайн суурь зүйлээс хейжийн зүйл болох хэсгийг сонгосноор энэ төрлийн хейжийн харилцааны хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийн ашиг, алдагдалд бараг ижил үр нөлөө үзүүлж болох юм. Жишээлбэл, банк нь ижил эрсдэл ба нөхцөл бүхий 100ТН-ийн хөрөнгөтэй, 90ТН-ийн өр төлбөртэй бөгөөд цэвэр 10ТН-ийн эрсдэлд хейж хийсэн бол уг банк нь тэдгээр хөрөнгөөс 10ТН-ийг хейжийн зүйл гэж сонгож болно. Хэрэв ийм хөрөнгө, өр төлбөр нь тогтмол хүүтэй хэрэглүүр бол бодит үнэ цэнийн хейжийн хувьд, харин хувьсах хүүтэй хэрэглүүр бол мөнгөн гүйлгээний хейжийн хувьд ийм сонголтыг хийж болно. Үүнтэй адилаар, хэрэв байгууллага нь 100ТН-ийн

<sup>15</sup> Light Sweet Crude Oil-“Свийт” шингэн, түүхий газрын тос. Нью Йоркын барааны биржид түүнийг газрын тосны бенчмарк болгон ашигладаг. Ред.Ч.Д.

<sup>16</sup> Brent буюу Brent гэдэг нь газрын тосны тогтоцын Broom, Rannoch, Etive, Ness, Tarbert гэсэн 5 давхаргын нэрийн эхний үсгээр зохиосон товчилсон үг юм. Brent нь шингэн, тунгалаг газрын тосны дэлхий худалдааны ангилал бөгөөд түүний үнийг худалдаа, арилжаа хийх бенчмарк үнэ болгон ашигладаг. Түүхий нефтийг Баруун Техасын, Brentийн, Дубайн, Таписын, Минасын, ОПЕК-ийн гэж байршлаар ангилдаг бөгөөд Brent нь Хойд тэнгисийн Brent, Нинианы зэрэг нийт 15 ордуудаас олборлодог газрын тос юм байна. Ред.Ч.Д.

гадаад валютаар худалдан авалт хийх ба 90ТН-ийн гадаад валютаар борлуулалт хийх арилжааны баталгаа гаргасан бол уг байгууллага нь үүсмэл хэрэглүүр худалдаж авснаар энэхүү 10ТН-ийн цэвэр дүнд хейж хийх бөгөөд тэрхүү үүсмэл хэрэглүүрийг 100ТН-ийн худалдан авалт хийх арилжааны баталгааны 10ТН-тэй холбоотой хейжийн хэрэглүүр гэж сонгож болно.

*Хейжийн нягтлан бодох бүртгэл (95-113-р параграф)*

МЗУ142. Бодит үнэ цэнийн хейжийн жишээ нь; хүүний түвшний өөрчлөлтийн үр дүнд, тогтмол хүүтэй өрийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэд гарах өөрчлөлтийн хейж юм. Хэрэглүүрийн гаргагч эсвэл эзэмшигч нь ийм хейжийг хийж болно.

МЗУ143. Мөнгөн гүйлгээний хейжийн жишээ нь; хөвөгч хүүтэй өрийг тогтмол хүүтэй өр болгон өөрчлөх свопын хэрэглээ юм (өөрөөр хэлбэл, хейж хийж буй ирээдүйн мөнгөн гүйлгээ нь ирээдүйн хүүний төлбөр байх тохиолдолд ирээдүйн ажил гүйлгээний хейж).

МЗУ144. Арилжааны баталгааны хейж (жишээлбэл; цахилгаан станц нь тогтмол үнээр түлш худалдан авах өөрийн хүлээн зөвшөөрөөгүй байгаа гэрээний хариуцлагатай холбоотойгоор түлшний үнийн өөрчлөлтийн хувьд хийх хейж) нь бодит үнэ цэнийн өөрчлөлтийн эрсдлийн хейж юм. Иймээс энэ хейж нь бодит үнэ цэнийн хейж юм. Гэвч арилжааны баталгааны гадаад валютын эрсдлийн хейжийг 97-р параграфын дагуу мөн мөнгөн гүйлгээний хейж гэж тайлагнаж болно.

**Хейжийн үр дүнтэй байдлыг үнэлэх**

МЗУ145. Дараах хоёр нөхцөл хоёулаа хангагдах зөвхөн тийм тохиолдолд хейжийг өндөр үр дүнтэй гэж үзнэ:

(а) Хейжийн эхэнд болон дараагийн тайлант үеүдэд уг хейж нь түүнийг сонгосон тайлант үеийн туршид тухайн хейж хийсэн эрсдэлд хамааруулах бодит үнэ цэнийн буюу мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг нөхөхөд өндөр үр дүнтэй байхаар хүлээгдэж байх. Ийм хүлээлтийг янз бүрийн арга замаар харуулж болно. Үүнд: тухайн хейж хийсэн эрсдэлд хамаарах хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн буюу мөнгөн гүйлгээний өмнөх өөрчлөлтүүдийг уг хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн буюу мөнгөн гүйлгээний өмнөх өөрчлөлтүүдтэй зэрэгцүүлэх, эсвэл хейжийн зүйлийн бодит үнэ цэнэ, мөнгөн гүйлгээ ба хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ, мөнгөн гүйлгээний хоорондох статистик өндөр хамаарлыг харуулах. МЗУ140-р параграфт заасанчлан, хейжийн үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэхийн тулд байгууллага нь нэг-нэг гэдгээс өөр хейжийн харьцааг сонгож болох юм.

(б) Хейжийн бодит үр дүн нь 80-125 хувь гэсэн муж дотор байх. Жишээлбэл; хейжийн хэрэглүүрийн гарз нь 120ТН, мөнгөн хэрэглүүрийн олз нь 100ТН байх тийм бодит үр дүнтэй бол

нөхөлтийг 120/100 буюу 120 хувь, эсвэл 100/120 буюу 83 хувь гэж хэмжиж болно. Энэ жишээнд хейж нь (а)-д заасан нөхцлийг хангаж байна гэж үзээд байгууллага нь тухайн хейжийг өндөр үр дүнтэй гэж дүгнэнэ.

МЗУ146. Байгууллага наад зах нь өөрийн жилийн санхүүгийн тайланг бэлтгэх үедээ үр дүнтэй байдлыг үнэлнэ.

МЗУ147. Энэ Стандарт нь хейжийн үр дүнтэй байдлыг үнэлэх цорын ганц аргыг тусгайлан заагаагүй. Хейжийн үр дүнтэй байдлыг үнэлэхдээ байгууллагын хэрэглэх арга нь түүний эрсдлийн удирдлагын стратегиас хамаарна. Жишээлбэл; байгууллагын эрсдлийн удирдлагын стратеги нь хейж хийсэн төлөв байдлын өөрчлөлтийг тусгахын тулд хейжийн хэрэглүүрийн дүнг үечлэн тохируулдаг бол тухайн байгууллага нь хейжийн хэрэглүүрийн дүнг дараагийн удаа тохируулах зөвхөн тэрхүү тайлант үе хүртэл уг хейж өндөр үр дүнтэй байхаар хүлээгдэж буй гэдгийг батлан харуулах шаардлагатай юм. Зарим тохиолдолд байгууллага нь өөр өөр төрлийн хейжийн хувьд ялгаатай аргуудыг хэрэглэдэг. Байгууллагын хейжийн стратегийн талаархи түүний баримтжуулалт нь хейжийн үр дүнтэй байдлыг үнэлэх өөрийн горимуудыг агуулсан байдаг. Эдгээр горимууд нь уг үнэлгээнд хейжийн хэрэглүүрийн бүх олз, гарзыг тусгасан эсэх, эсвэл тухайн хэрэглүүрийн цаг хугацааны үнэ цэнийг харгалзан хассан эсэхийг илэрхийлнэ.

МЗУ148. Хэрэв байгууллага нь тухайн зүйлийн эрсдлийн 100-аас бага хувьд, жишээлбэл 85 хувьд хейж хийж байвал эрсдлийн 85 хувь байдлаар уг хейжийн зүйлийг сонгох бөгөөд тэрхүү сонгосон 85 хувийн эрсдлийн өөрчлөлтөнд үндэслэн хейжийн үр дүнгүй байдлыг хэмжинэ. Гэвч уг сонгосон 85 хувийн эрсдэлд хейж хийх тохиолдолд нэг-нэг гэдгээс өөр харьцаа нь МЗУ140-р параграфт тайлбарласанчлан, хейжийн хүлээгдэж буй үр дүнтэй байдлыг сайжруулахаар байвал тухайн байгууллага нь нэг-нэг гэдгээс өөр хейжийн харьцааг ашиглаж болох юм.

МЗУ149. Хэрэв хейжийн хэрэглүүрийн болон хейж хийсэн хөрөнгө, өр төлбөр, арилжааны баталгаа, хэрэгжих өндөр магадлалтай урьдчилан таамагласан ажил гүйлгээний нөхцлүүд ижил бол хейжийг анх хийсэн үе ба түүнээс хойших хугацааны аль алины хувьд тухайн хейж хийж буй эрсдэлд хамаарах бодит үнэ цэнийн болон мөнгөн гүйлгээний өөрчлөлтүүд нь харилцан бие биенийгээ бүрэн нөхөж болох юм. Жишээлбэл; хейжийн хэрэглүүрийн болон хейжийн зүйлийн нэрлэсэн ба үндсэн дүнгүүд, хугацаа, хүүний түвшинг дахин хянах өдрүүд, хүү ба үндсэн төлбөрийг хүлээн авах буюу төлөх өдрүүд, хүүний түвшинг хэмжих сууриуд нь ижил бол хүүний түвшний своп нь үр дүнтэй хейж байх магадлалтай юм. Түүнчлэн, барааны хэрэгжих өндөр магадлалтай урьдчилан таамагласан худалдан авалтын хувьд форвард гэрээгээр хийсэн хейж нь дараах тохиолдолд өндөр үр дүнтэй байх магадлалтай байдаг:



- (а) Тухайн форвард гэрээ нь хейж хийсэн, урьдчилан таамагласан худалдан авалттай ижил цаг хугацаа ба байршилд ижил барааг тэнцүү тоо хэмжээгээр худалдан авах гэрээ байх;
  - (б) Форвард гэрээний бодит үнэ цэнэ нь түүний эхлэлийн өдөр тэг байх; ба
  - (в) Тухайн форвард гэрээний хөнгөлөлт буюу урамшууллын өөрчлөлтийг үр дүнтэй байдлын үнэлгээнд оруулахгүй ба ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг эсвэл хэрэгжих өндөр магадлалтай урьдчилан таамагласан ажил гүйлгээний хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний өөрчлөлт нь уг барааны форвард үнэд үндэслэдэг байх.
- МЗУ150. Зарим тохиолдолд хейжийн хэрэглүүр нь хейж хийсэн эрсдлийн зөвхөн тодорхой нэг хэсгийг нөхдөг. Жишээлбэл; хейжийн хэрэглүүр ба хейжийн зүйл нь нэгэн зэрэг хувьсан өөрчлөгддөггүй өөр өөр валютаар илэрхийлэгдсэн бол хейж нь бүрэн үр дүнтэй байдаггүй. Үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн тодорхой хэсэг нь тухайн хэрэглүүрийн оролцогч нөгөө талын зээлийн эрсдлээс хамааралтай байдаг бол ийм үүсмэл хэрэглүүрийг ашиглан хийсэн хүүний түвшний эрсдлийн хейж нь мөн бүрэн үр дүнтэй байхгүй.
- МЗУ151. Хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангахын тулд хейж нь зөвхөн тухайн байгууллагын үйл ажиллагааны ерөнхий эрсдэлтэй биш, харин тусгайлан тогтоосон ба сонгосон эрсдэлтэй холбоотой байх ёстой бөгөөд уг байгууллагын ашиг, алдагдалд эцэстээ нөлөө үзүүлэх ёстой. Биет хөрөнгийн элэгдэл хуучралтын эрсдлийн эсвэл байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн сэргээхтэй холбоотой хууль тогтоомжийн өөрчлөлтийн эрсдлийн хейж нь хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангахгүй юм; эдгээр эрсдлийг найдвартай хэмжих боломжгүй учраас үр дүнтэй байдлыг хэмжиж чадахгүй.
- МЗУ152. 83(а) параграф нь опционы гэрээний дотоод үнэ цэнэ ба цаг хугацааны үнэ цэнийг салган зааглаж, тухайн опционы гэрээний зөвхөн дотоод үнэ цэнийн өөрчлөлтийг хейжийн хэрэглүүр гэж сонгохыг байгууллагад зөвшөөрдөг. Хэрэв урьдчилан таамагласан ажил гүйлгээний болон хейжийн хэрэглүүрийн үндсэн нөхцлүүд ижил бол дээр дурдсан сонголт нь урьдчилан таамагласан ажил гүйлгээний зөвхөн хейж хийсэн нэг талт эрсдэлд хамаарах мөнгөн гүйлгээний өөрчлөлтүүдийг нөхөхөд бүрэн үр дүнтэй байх тийм хейжийн харилцаанд хүргэж болох юм.
- МЗУ153. Харин байгууллага өөрийн худалдан авсан опционыг бүхэлд нь, уг урьдчилан таамагласан ажил гүйлгээнээс бий болох нэг талт эрсдлийн хейжийн хэрэглүүр гэж сонгосон бол ийм хейжийн харилцаа нь бүрэн үр дүнтэй байхгүй. Яагаад гэвэл, тухайн опционы хувьд төлсөн урамшуулал нь МЗУ135-р параграфт заасанчлан, цаг хугацааны үнэ цэнийг агуулдаг, харин уг сонгосон нэг талт эрсдэл нь опционы цаг хугацааны үнэ цэнийг агуулахгүй. Иймээс энэ тохиолдолд уг төлсөн опционы урамшууллын цаг хугацааны үнэ цэнэ болон тухайн сонгож, хейж хийсэн эрсдэлтэй холбоотой мөнгөн гүйлгээнүүдийн хооронд нөхөлт үүсэхгүй.

МЗУ154. Хүүний түвшний эрсдлийн хувьд, хэрэв цэвэр эрсдэл нь түүнийг үүсгэдэг тодорхой хөрөнгө, өр төлбөртэй (хөрөнгө, өр төлбөрийн тодорхой бүлэгтэй эсвэл тэдгээрийн тодорхой хэсэгтэй) холбоотой бөгөөд хейжийн үр дүнтэй байдлыг тэдгээр хөрөнгө, өр төлбөртэй уялдуулан үнэлдэг бол тайлант үе тус бүрийн хувьд хүүний түвшний цэвэр эрсдлийг харуулсан, санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн дуусгавар болох хугацааны хуваарийг бэлтгэснээр хейжийн үр дүнтэй байдлыг үнэлж болно.

МЗУ155. Хейжийн үр дүнтэй байдлыг үнэлэхдээ, байгууллага нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг ерөнхийдөө харгалзан үздэг. Хейжийн зүйлийн тогтмол хүүний түвшин нь бодит үнэ цэнийн хейж гэж сонгосон свопын тогтмол хүүний түвшинтэй яг нийцэн уялдсан байх албагүй юм. Түүнчлэн, хүүтэй хөрөнгө, өр төлбөрийн хувьсах хүүний түвшин нь мөнгөн гүйлгээний хейж гэж сонгосон свопын хувьсах хүүний түвшинтэй яг тэнцүү байх албагүй байдаг. Свопын бодит үнэ цэнэ нь түүний цэвэр барагдуулалтаар тодорхойлогддог. Хэрэв свопын тогтмол болон хувьсах хүүний түвшнүүд нь ижил дүнгээр өөрчлөгддөг бол уг цэвэр барагдуулалтанд нөлөө үзүүлэхгүйгээр тэдгээр тогтмол ба хувьсах түвшнүүдийг өөрчилж болно.

МЗУ156. Хэрэв байгууллага нь хейжийн үр дүнтэй байдлын шалгуурыг хангахгүй бол уг байгууллага нь хейжийн үр дүнтэй байдалд нийцсэн гэдгээ батлан харуулж чадах сүүлийн өдрөөс эхлэн хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэхгүй, зогсооно. Харин хейжийн харилцаа нь үр дүнтэй байдлын шалгуурыг хангахгүй болоход хүргэсэн үйл явдал буюу нөхцөл байдлын өөрчлөлтийг тухайн байгууллага тогтоосон бөгөөд тэрхүү үйл явдал буюу нөхцөл байдлын өөрчлөлт гарч тохиолдохоос өмнө уг хейж үр дүнтэй байсныг батлан харуулсан бол байгууллага нь тэрхүү үйл явдал буюу нөхцөл байдлын өөрчлөлтийн өдрөөс эхлэн хейжийн нягтлан бодох бүртгэлийг зогсооно.

**Хүүний түвшний эрсдлийн багц хейжид хамаарах бодит үнэ цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэл**

МЗУ157. Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн багцтай холбоотой хүүний түвшний эрсдлийн бодит үнэ цэнийн хейжийн хувьд байгууллага нь доорх (а)-(к)-д болон МЗУ158-МЗУ175-р параграфт заасан горимуудыг даган мөрдвөл энэ Стандартын шаардлагуудыг хангах юм.

- (а) Хүүний түвшний эрсдлийнх хувьд хейж хийхийг хүсэж буй зүйлсийн багцыг байгууллага нь өөрийн эрсдлийн удирдлагын үйл ажиллагааны нэг хэсэг байдлаар тодорхойлно. Тухайн багц нь зөвхөн хөрөнгөөс эсвэл зөвхөн өр төлбөрөөс, эсвэл хөрөнгө, өр төлбөрийн аль алинаас бүрдэж болно. Байгууллага нь хоёр ба түүнээс олон багцыг тодорхойлж болох (жишээлбэл; байгууллага нь өөрийн борлуулах боломжтой хөрөнгүүдийг тусдаа багцад бүлэглэж болох) бөгөөд энэ тохиолдолд доорх заавар удирдамжийг багц нэг бүрд тусад нь мөрдөнө.

- (б) Байгууллага нь гэрээнд заасан бус, харин хүлээгдэж буй дахин хянах өдрүүдэд үндэслэн уг багцыг тэдгээр дахин хянах тайлант үеүдээр шинжилнэ. Дахин хянах тайлант үеүдээр хийгдэх шинжилгээг янз бүрийн арга замаар гүйцэтгэж болно. Үүнд: мөнгөн гүйлгээг түүний үүсэхээр хүлээгдэж буй тайлант үеүдээр хуваарилан гаргах эсвэл нэрлэсэн үндсэн төлбөрүүдийг дахин хяналт хийхээр хүлээгдэж буй өдөр хүртэлх бүх тайлант үеүдэд хуваарилан гаргах.
- (в) Энэхүү шинжилгээнд үндэслэн, байгууллага нь хейж хийхийг хүсэж буй дүнг тодорхойлно. Тухайн тодорхойлсон багцаас авсан бөгөөд хейж хийгдэж буй гэж сонгохыг хүссэн дүнтэй тэнцүү байх тийм хөрөнгө эсвэл өр төлбөрийн дүнг (гэхдээ цэвэр дүн биш) уг байгууллага нь хейжийн зүйл гэж сонгоно. Мөн энэ дүн нь МЗУ169(б) параграфын дагуу үр дүнтэй байдлыг сориход ашиглагдах хувийн жингийн хэмжигдэхүүнийг тодорхойлно.
- (г) Байгууллага нь хейж хийгдэж буй хүүний түвшний эрсдлийг сонгоно. Энэхүү эрсдэл нь хейж хийгдэж буй төлөв байдал дахь зүйлс тус бүрд хамаарах бенчмарк хүүний түвшин (жишээ нь; свопын түвшин) гэх мэт хүүний түвшний эрсдлийн тодорхой нэг хэсэг байж болно.
- (д) Байгууллага нь дахин хянах тайлант үе тус бүрд нэг буюу хэд хэдэн хейжийн хэрэглүүрийг сонгоно.
- (е) Дээрх (в)-(д)-д хийсэн сонголтыг ашигласнаар, байгууллага нь уг хейжийг сонгосон тайлант үеийн туршид тухайн хейж өндөр үр дүнтэй байхаар хүлээгдэж буй эсэхийг хейжийн эхэнд болон дараагийн тайлант үеүдэд үнэлнэ.
- (ж) Байгууллага нь (б)-д дурдсан, хүлээгдэж буй дахин хянах өдрүүдэд үндэслэн тухайн хейж хийсэн эрсдэлд ((г)-д сонгосон) хамаарах хейжийн зүйлийн ((в)-д сонгосон) бодит үнэ цэнийн өөрчлөлтийг хэмжинэ. Үр дүнтэй байдлыг үнэлэх уг байгууллагын баримтжуулсан аргыг ашиглан үнэлгээ хийж үзэхэд тухайн хейж нь өндөр үр дүнтэй гэдгийг бодитойгоор тодорхойлсон бол байгууллага нь хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд олз эсвэл гарз гэж хүлээн зөвшөөрөх бөгөөд 100-р параграфт дурдсан, санхүүгийн байдлын тайлангийн хоёр мөрийн зүйлийн аль нэгэнд тусгана. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бие даасан хөрөнгө эсвэл өр төлбөрт хуваарилах шаардлагагүй юм.
- (и) Байгууллага нь хейжийн хэрэглүүрийн ((д)-д сонгосон) бодит үнэ цэнийн өөрчлөлтийг хэмжиж, ашиг, алдагдалд олз эсвэл гарз гэж хүлээн зөвшөөрнө. Тухайн хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг санхүүгийн байдлын тайланд хөрөнгө эсвэл өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.
- (к) Аливаа үр дүнгүй байдлыг дээрх (ж) болон (и)-д дурдсан бодит үнэ цэнийн өөрчлөлтүүдийн хоорондох зөрүүгээр ашиг, алдагдалд

хүлээн зөвшөөрнө (бусад УСНББОУС-д заасантай ижил материаллаг байдлын ач холбогдлыг харгалзсанаар үр дүнтэй байдлыг хэмждэг).

- МЗУ158. Энэхүү хандлагыг доор илүү дэлгэрэнгүй авч үзсэн. Энэхүү хандлагыг санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн багцтай холбоотой хүүний түвшний эрсдлийн зөвхөн бодит үнэ цэнийн хейжид хэрэглэнэ.
- МЗУ159. МЗУ157(а) параграфт тодорхойлсон багц нь хөрөнгө ба өр төлбөрийг агуулсан байж болно. Нөгөө талаас, энэ нь зөвхөн хөрөнгө эсвэл зөвхөн өр төлбөрийг агуулсан багц байж болох юм. Байгууллагын хейж хийхийг хүсэж буй хөрөнгө буюу өр төлбөрийн дүнг тодорхойлохын тулд багцыг ашигладаг. Гэхдээ тухайн багцыг өөрийг нь хейжийн зүйл гэж сонгохгүй.
- МЗУ160. МЗУ157(б) параграфыг мөрдөхдөө, байгууллага нь тухайн зүйлийн хүлээгдэж буй дахин хянах өдрийг тэрхүү зүйлийн дуусгавар болохоор хүлээгдэж буй өдөр эсвэл зах зээлийн түвшнээр дахин хянах өдрийн аль өмнөхөөр тодорхойлно. Хүлээгдэж буй дахин хянах өдрийг түүхэн туршлага ба бусад бэлэн байгаа мэдээлэлд, үүн дотроо урьдчилсан төлбөрийн хувийн жин, хүүний түвшин болон тэдгээрийн хоорондох харилцан хамаарал зэргийн талаархи мэдээлэл ба хүлээлтэнд үндэслэн уг хейжийн эхэнд болон хейжийн хугацааны туршид тооцоолно. Өөрийн тодорхой туршлага байхгүй эсвэл хангалттай туршлагагүй байгууллагууд нь зэрэгцүүлж болох санхүүгийн хэрэглүүрийн талаархи адилтгах бүлгийн туршлагыг харгалзана. Ийм тооцооллыг үечлэн хянах бөгөөд туршлагыг харгалзан шинэчлэн баяжуулна. Тогтмол хүүтэй бөгөөд урьдчилан төлж болох зүйлсийн хувьд хүлээгдэж буй дахин хянах өдөр нь тухайн зүйлийг зах зээлийн түвшнээр өмнө нь дахин хянаснаас бусад тохиолдолд түүнийг урьдчилан төлөхөөр хүлээгдэж буй өдөр байна. Ижил төсөөтэй зүйлсийн бүлгийн хувьд, хүлээгдэж буй дахин хянах өдрүүдэд үндэслэн тайлант үеүдээр хийсэн шинжилгээ нь тайлант үе бүр дэх тэдгээр бие даасан зүйлсээр биш, харин уг бүлгийн хувийн жингээр гаргасан хуваарилалт хэлбэртэй байна. Байгууллага нь ийм хуваарилалтын зорилгын хувьд бусад арга зүйг хэрэглэж болно. Жишээлбэл; байгууллага нь хүлээгдэж буй дахин хянах өдрүүдэд үндэслэн тайлант үеүдэд зээлийг хуваарилан хорогдуулахын тулд урьдчилсан төлбөрийн хувийн жингийн үржүүлэгчийг ашиглаж болно. Гэхдээ ийм хуваарилалтын арга зүй нь тухайн байгууллагын эрсдлийн удирдлагын горим ба зорилготой нийцсэн байна.
- МЗУ161. МЗУ157(в) параграфт заасан сонголтыг дараах жишээгээр авч үзье. Байгууллага нь дахин хянах тайлант үе бүрийн хувьд тогтмол хүүтэй 100ТН-ийн хөрөнгөтэй, тогтмол хүүтэй 80ТН-ийн өр төлбөртэй байна гэж тооцоолсон бөгөөд 20ТН-ийн нийт цэвэр дүнд хейж хийхээр шийдвэрлэсэн бол 20ТН бүхий хөрөнгийг (байгууллага нь шалгуур хангах бэлэн боломжтой байгаа хөрөнгө буюу өр төлбөрийн дурын дүнг, өөрөөр хэлбэл энэ жишээнд 0ТН-ээс 100ТН-ийн хоорондох хөрөнгийн дурын дүнг сонгохыг энэ Стандартаар зөвшөөрдөг тул тэрхүү хөрөнгийн хэсгийг) хейжийн зүйл гэж сонгоно. Сонголтыг бие даасан хөрөнгөөр биш, харин

“мөнгөн дүн”-гээр (жишээлбэл, доллар, евро, фунт стирлингийн эсвэл рандын дүн) илэрхийлнэ. Эндээс дараах дүгнэлтийг хийж болно: тухайн хейж хийгдэж буй дүнг гарган авч буй бүх хөрөнгө (эсвэл өр төлбөр) өөрөөр хэлбэл, дээрх жишээн дэх 100ТН-ийн бүх хөрөнгө нь:

- (а) Хүүний түвшний өөрчлөлтийн улмаас түүний бодит үнэ цэнэд гарах өөрчлөлтийн хувьд хейж хийгдэж буй зүйлс байх ёстой; ба
  - (б) Хэрэв тэднийг тус тусад нь хейж хийхээр сонгосон бол бодит үнэ цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангаж чадах зүйлс байх ёстой. Тухайлбал; шаардсан даруйд олгох шинж бүхий санхүүгийн өр төлбөрийн (харилцах данс, хугацаагүй хадгаламж ба зарим төрлийн хугацаат хадгаламж гэх мэт) бодит үнэ цэнэ нь тухайн дүнг төлөхийг шаардаж болох хамгийн эхний өдрөөс эхлэн дискаунтчилсан, уг шаардсан даруйд олгох өглөгийн дүнгээс багагүй байна гэж энэ Стандартын 52-р параграфт тусгайлан заасан учраас ийм зүйл нь түүний эзэмшигч төлбөрийг шаардаж болох хамгийн богино тайлант үеэс цаашхи аливаа тайлант үед бодит үнэ цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангахгүй юм. Дээрх жишээнд хейж хийсэн төлөв байдал нь хөрөнгийн дүн байна. Тийм учраас ийм өр төлбөр нь сонгосон хейжийн зүйлийн нэг хэсэг болохгүй боловч байгууллага нь хейж хийж буй гэж сонгох хөрөнгийн дүнг тодорхойлохын тулд уг өр төлбөрийг ашигладаг. Хэрэв байгууллагын хейж хийхийг хүссэн төлөв байдал нь өр төлбөрийн дүн байсан бол арай эрт буцаан төлөхийг тухайн байгууллагаас шаардаж чадах тийм өр төлбөрөөс бусад, тогтмол хүүтэй өр төлбөрөөс уг сонгосон хейжийн зүйлийг төлөөлөн илэрхийлэх дүнг гарган авах ёстой бөгөөд МЗУ169(б) параграфын дагуу хейжийн үр дүнтэй байдлыг үнэлэхэд ашигласан хувийн жингийн хэмжигдэхүүнийг тэрхүү бусад өр төлбөрийн хувийн жин байдлаар тооцоолно. Жишээлбэл; байгууллага нь дахин хянах тайлант үе бүрийн хувьд тогтмол хүүтэй 100ТН-ийн өр төлбөртэй, тогтмол хүүтэй 70ТН-ийн хөрөнгөтэй байхаар тооцоолсон гэж үзье. Энэхүү 100ТН-ийн өр төлбөр нь шаардсан даруйд олгох 40ТН-ийн өр төлбөр, шаардсан даруйд олгох тийм шинж чанаргүй 60ТН-ийн өр төлбөрөөс бүрддэг. Хэрэв байгууллага нь 30ТН-ийн бүх цэвэр төлөв байдал буюу цэвэр дүнд хейж хийхээр шийдвэрлэсэн бол тухайн байгууллага нь шаардсан даруйд олгох шинж чанаргүй өр төлбөрийн 30ТН буюу 50 хувийг  $(30ТН/(100ТН-40ТН))=50$  хувь) хейжийн зүйл гэж сонгоно.
- МЗУ162. Байгууллага нь 98(а) параграфт заасан, сонголт ба баримтжуулалтын бусад шаардлагуудыг бас даган мөрдөнө. Хүүний түвшний эрсдлийн багц хейжийн хувьд, энэхүү сонголт ба баримтжуулалт нь хейж хийх дүнг тогтоох болон хейжийн үр дүнтэй байдлыг хэмжихэд ашигласан бүх хувьсагчдын талаархи тухайн байгууллагын бодлогыг тусгайлан заасан байдаг. Үүнд дараах зүйлс хамаарна:
- (а) Багцын хейжид аль хөрөнгө буюу өр төлбөрийг оруулах эсэх, уг багцаас тэдгээрийг хасахдаа ашиглах суурь.

- (б) Байгууллага нь дахин хянах өдрүүдийг хэрхэн тооцоолох, үүн дотроо урьдчилсан төлбөрийн хувь хэмжээний тооцоолол ба тэдгээр тооцооллыг өөрчлөх суурийн үндэслэл болох хүүний түвшний талаархи таамаглалууд. Тухайн хейж хийсэн багцад хөрөнгө, өр төлбөрийг оруулах үед хийсэн анхны тооцоолол ба тэдгээр тооцооллын дараагийн аливаа засвар өөрчлөлтийн аль алины хувьд нэг ижил аргыг ашиглана.
- (в) Дахин хянах тайлант үеүдийн тоо ба үргэлжлэх хугацаа.
- (г) Байгууллага нь үр дүнтэй байдлыг хэр тогтмол сорьж шалгах ба МЗУ169-р параграфт заасан хоёр аргын алийг ашиглах эсэх.
- (д) Хейжийн зүйл гэж сонгох тухайн хөрөнгө, өр төлбөрийн дүнг тодорхойлохдоо байгууллагын ашигладаг арга зүй, түүнчлэн байгууллага нь МЗУ169(б) параграфт дурдсан аргыг ашиглаж, үр дүнтэй байдлыг сорьж шалгах үедээ ашиглах хувийн жингийн хэмжүүр.
- (е) Байгууллага нь МЗУ169(б) параграфт дурдсан аргыг ашиглаж, үр дүнтэй байдлыг сорьж шалгадаг тохиолдолд тухайн байгууллага нь дахин хянах тайлант үе тус бүрээр, бүх тайлант үеүдийн нэгдсэн байдлаар эсвэл энэ хоёрыг зарим талаар хослуулснаар үр дүнтэй байдлыг сорьж шалгах эсэх.

Тухайн хейжийн харилцааны сонголт ба баримтжуулалтанд тусгайлан заасан бодлогууд нь уг байгууллагын эрсдлийн удирдлагын горим, зорилготой нийцсэн байна. Бодлогын өөрчлөлтийг санамсаргүй, тохиолдлын байдлаар хийж болохгүй. Аливаа өөрчлөлт нь зах зээлийн нөхцөл байдлын болон бусад хүчин зүйлсийн өөрчлөлтөнд үндэслэсэн, түүгээр зөвтгөн батлагдсан байх бөгөөд тухайн байгууллагын эрсдлийн удирдлагын горим, зорилготой нийцсэн, тэдгээрт тулгуурласан байна.

МЗУ163. МЗУ157(д) параграфт дурдсан, хейжийн хэрэглүүр нь нэг үүсмэл хэрэглүүр эсвэл үүсмэл хэрэглүүрүүдийн багц байж болох бөгөөд уг багцад багтсан хэрэглүүр бүр нь МЗУ157(г) параграфт сонгосон, уг хейж хийсэн хүүний түвшний эрсдэлд өртөнө. Ийм үүсмэл хэрэглүүрүүдийн багц нь эрсдлийг нөхөх төлөв байдлыг агуулсан байж болно. Гэвч энэ нь гаргасан опцион эсвэл гаргасан цэвэр опционыг агуулж болохгүй. Яагаад гэвэл, энэ Стандартын 86-р параграф болон МЗУ127-р параграф нь ийм опционыг (гаргасан опционыг худалдан авсан опционы нөхөлт гэж сонгосноос бусад тохиолдолд) хейжийн хэрэглүүр гэж сонгохыг зөвшөөрдөггүй. Хэрэв хейжийн хэрэглүүр нь МЗУ157(в) параграфт сонгосон дүнд тухайн дахин хянах нэгээс олон тайлант үеийн туршид хейж хийж байгаа бол түүнийг уг хейж хийж буй бүх тайлант үеүдэд хуваарилна. Гэвч энэ Стандартын 84-р параграф нь хейжийн хэрэглүүр эргэлтэнд байх хугацааны турш дахь тухайн тайлант үеийн зөвхөн тодорхой нэг хэсгийн хувьд хейжийн харилцааг сонгохыг зөвшөөрдөггүй учраас уг хейжийн хэрэглүүрийг бүхэлд нь тэдгээр дахин хянах тайлант үеүдэд хуваарилах ёстой.

- МЗУ164. Байгууллага нь урьдчилан төлж болох зүйлийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг МЗУ157(ж) параграфын дагуу хэмждэг тохиолдолд хүүний түвшний өөрчлөлт нь уг урьдчилан төлж болох зүйлийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөнд хоёр арга замаар нөлөө үзүүлдэг: нэгд, энэ нь гэрээний мөнгөн гүйлгээний бодит үнэ цэнэд нөлөөлнө, хоёрт, уг урьдчилан төлж болох зүйлд агуулагдаж буй тухайн урьдчилан төлөх опционы бодит үнэ цэнэд нөлөөлдөг. Энэ Стандартын 90-р параграф нь хэрэв үр дүнтэй байдлыг хэмжиж чадах бол нийтлэг эрсдлийг хуваалцдаг санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн хэсгийг хейжийн зүйл гэж сонгохыг байгууллагад зөвшөөрдөг. Урьдчилан төлж болох зүйлсийн хувьд, 91-р параграф нь хүүний түвшинг дахин хянах гэрээний огноонд биш, харин хүлээгдэж буй огноонд үндэслэн уг хейж хийсэн хүүний түвшний өөрчлөлтөнд хамаарах бодит үнэ цэнийн өөрчлөлттэй холбоотойгоор тухайн хейжийн зүйлийг сонгосноор үүнийг гүйцэтгэхийг зөвшөөрдөг. Гэхдээ уг хейж хийсэн хүүний түвшний өөрчлөлтүүдийн тэдгээр хүлээгдэж буй дахин хянах өдрөөрх үр нөлөөг тухайн хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тодорхойлохдоо харгалзан оруулна. Иймээс уг хүлээгдэж буй дахин хянах өдрүүдийг өөрчилсөн (жишээлбэл; хүлээгдэж буй урьдчилсан төлбөрийн өөрчлөлтүүдийг тусгахын тулд) эсвэл дахин хянах бодит өдөр нь хүлээгдэж буй өдрөөс өөр байх тохиолдолд МЗУ169-р параграфт заасанчлан, үр дүнгүй байдал үүсдэг. Харин эсрэгээр, хүлээгдэж буй дахин хянах өдрийн өөрчлөлтүүд нь дараах тохиолдолд уг хейж хийсэн эрсдэлд хамааралгүй тул тухайн хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тодорхойлохдоо түүнийг харгалзан үзэхгүй. Үүнд: (а) энэ нь хейж хийсэн хүүний түвшний өөрчлөлтөөс бусад хүчин зүйлсээс илэрхий шалтгаалж, үүссэн, (б) хейж хийсэн хүүний түвшний өөрчлөлттэй холбоо хамааралгүй, (в) хейж хийсэн хүүний түвшинд хамаарах өөрчлөлтүүдээс найдвартайгаар салган зааглаж чадах (жишээлбэл; урьдчилан төлөх хувь хэмжээний өөрчлөлт нь хүүний түвшний өөрчлөлт биш, харин хүн ам зүйн хүчин зүйлс эсвэл татварын зохицуулалтын өөрчлөлтөөс илт шалтгаалж, үүссэн байх). Хэрэв хүлээгдэж буй дахин хянах өдрүүд өөрчлөгдөхөд хүргэж буй хүчин зүйлс тодорхой бус эсвэл тухайн байгууллага нь хейж хийсэн хүүний түвшнээс үүссэн өөрчлөлтийг бусад хүчин зүйлсээс үүссэн өөрчлөлтөөс найдвартайгаар салган зааглах боломжгүй бол уг өөрчлөлтийг хейж хийсэн хүүний түвшний өөрчлөлтөөс үүссэн гэж үзнэ.
- МЗУ165. Энэ Стандарт нь МЗУ157(ж) параграфт дурдсан дүнг, тодруулбал; тухайн хейж хийсэн эрсдэлд хамаарах уг хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тодорхойлохдоо ашиглах арга зүйг тусгайлан заагаагүй. Хэрэв ийм хэмжилтийн хувьд статистикийн буюу бусад тооцооллын арга зүйг ашигладаг бол түүний үр дүн нь уг хейжийн зүйлийг бүрдүүлж байгаа бие даасан бүх хөрөнгө, өр төлбөрийн тусдаа хэмжилтээр гаргах байсан дүнтэй бараг ойролцоо байна гэж удирдлага итгэн хүлээсэн байх ёстой. Хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн өөрчлөлт нь хейжийн хэрэглүүрийн үнэ цэнийн өөрчлөлттэй тэнцүү гэж шууд үзэх нь тохиромжгүй юм.
- МЗУ166. Хэрэв дахин хянах тухайн тайлант үед хейжийн зүйл нь хөрөнгө байвал түүний үнэ цэнийн өөрчлөлтийг хөрөнгийн доторх тусдаа нэг мөрийн

зүйлд толилуулахыг 100-р параграфтаар шаардсан байдаг. Харин эсрэгээр, дахин хянах тухайн тайлант үед хейжийн зүйл нь өр төлбөр байвал түүний үнэ цэнийн өөрчлөлтийг өр төлбөрийн доторх тусдаа нэг мөрийн зүйлд толилуулна. Эдгээр нь МЗУ157(ж) параграфт дурдсан тусдаа мөрийн зүйлс юм. Бие даасан хөрөнгөнд (эсвэл өр төлбөрт) тусгайлан хуваарилалт хийхийг шаардаагүй.

МЗУ167. Хейж хийсэн эрсдэлд хамаарах хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн өөрчлөлт нь үүсмэл хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс өөр байх хэмжээгээр үр дүнгүй байдал үүснэ гэдгийг МЗУ157(к) параграфт тэмдэглэсэн. Ийм өөр зөрүүтэй байдал нь дараах гэх мэт олон шалтгаанаар үүсэж болно:

- (а) Дахин хянах бодит өдөр нь хүлээгдэж буй өдрөөс өөр байх эсвэл хүлээгдэж буй дахин хянах өдрийг өөрчлөх;
- (б) Хейж хийсэн багц дахь зүйлсийн үнэ цэнэ буурсан эсвэл тэдгээрийг үл хүлээн зөвшөөрсөн;
- (в) Хейжийн хэрэглүүр ба хейжийн зүйлийн төлбөр хийх өдрүүд өөр байх; ба
- (г) Бусад шалтгаан (жишээлбэл; хейж хийж буй гэж сонгосон багц дахь зарим хейжийн зүйл нь бенчмарк түвшнээс бага хүүтэй бөгөөд түүнээс хамаарсан үр дүнгүй байдал нь тухайн багц бүхэлдээ хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангахгүй болоход хүргэх тийм их биш байх).

Ийм үр дүнгүй байдлыг (бусад УСНББОУС-д заасантай ижил материаллаг байдлын ач холбогдлыг харгалзсанаар) тодорхойлж, ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

МЗУ168. Ерөнхийдөө хейжийн үр дүнтэй байдал нь дараах тохиолдолд сайжирдаг:

- (а) Байгууллага нь урьдчилсан төлбөрийн өөр өөр шинж чанар бүхий зүйлсийг тэдгээр урьдчилсан төлбөрийн ялгаатай байдлыг харгалзсан тийм арга замаар ангилан хуваарилсан тохиолдолд.
- (б) Тухайн багц дахь зүйлс маш олон байх. Багцад маш цөөхөн зүйлс байх тохиолдолд тэдгээрийн нэгийг түүний хүлээгдэж буй хугацаанаас эрт эсвэл хойш урьдчилан төлөхөд харьцангуй өндөр үр дүнгүй байдал үүсэх магадлалтай байдаг. Харин эсрэгээр, багцад олон зүйлс агуулагдсан байх тохиолдолд урьдчилсан төлбөрийн төлөв байдлыг илүү оновчтойгоор таамаглаж чадна.
- (в) Дахин хянах тайлант үеүд богино байх (жишээлбэл; 3 сард биш, харин 1 сард тутамд дахин хянах). Богино хугацаанд дахин хянах нь хейжийн зүйл ба хейжийн хэрэглүүрийн дахин хяналтын болон төлбөрийн өдрүүдийн (дахин хянах нэг тайлант үеийн доторх) хоорондох аливаа уялдаагүй байдлын үр нөлөөг бууруулдаг.



- (г) Хейжийн зүйлийн өөрчлөлтийг (жишээлбэл; урьдчилан төлөх хүлээлтийн өөрчлөлтөөс хамаарах) тусгахын тулд хейжийн хэрэглүүрийн дүнг тохируулах давтамж олон байх.

МЗУ169. Байгууллага нь үр дүнтэй байдлыг үечлэн сорьж шалгана. Хэрэв дахин хянах өдрийн тооцоолол нь үр дүнтэй байдлыг уг байгууллага үнэлсэн нэг өдрөөс дараагийн үнэлэх өдрийн хооронд өөрчлөгдсөн бол байгууллага нь үр дүнтэй байдлын дүнг дараах хоёр хувилбарын аль нэгээр тооцоолно:

- (а) Хейж хийсэн хүүний түвшний өөрчлөлтөнд (хейж хийсэн хүүний түвшний өөрчлөлт нь урьдчилж төлбөр хийх аливаа дагалдах опционы бодит үнэ цэнэд үзүүлэх үр нөлөө үүнд хамаарна) хамаарах уг хейжийн нийт зүйлийн үнэ цэнийн өөрчлөлт ба хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн (МЗУ157(и) параграфыг үзнэ үү) хоорондох зөрүүгээр; эсвэл
- (б) Дараах ойролцоо тооцооны дүнг ашиглах. Байгууллага нь:
- (i) Үр дүнтэй байдлыг сорьж шалгасан хамгийн сүүлийн өдрийн байдлаар тооцсон уг дахин хянах өдрүүдэд үндэслэн тухайн хейж хийсэн хөрөнгийн (буюу өр төлбөрийн) хувийн жинг дахин хянах тайлант үе бүрээр тооцоолно.
- (ii) Хянан засварласан тооцоололд үндэслэн, хейжийн зүйлийн дүнг тооцоохын тулд тухайн дахин хянах тайлант үе бүр дэх түүний хянан засварлаж, тооцсон дүнг энэхүү хувийн жингээр үржүүлнэ.
- (iii) Хейж хийсэн эрсдэлд хамаарах тухайн хейжийн зүйлийн хянан засварлаж, тооцсон бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тооцож, түүнийг МЗУ157(ж) параграфт зааснаар толилуулна.
- (iv) Дээрх (iii)-д тодорхойлсон дүн ба хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн хоорондох зөрүүтэй тэнцүү хэмжээгээр үр дүнгүй байдлыг хүлээн зөвшөөрнө (МЗУ157(и) параграфыг үзнэ үү).

МЗУ170. Үр дүнтэй байдлыг хэмжихдээ, байгууллага нь одоо байгаа хөрөнгө (өр төлбөр)-ийн тооцоолсон дахин хянах өдрүүдийн засварлалтыг шинэ хөрөнгө (өр төлбөр)-ийн үүсэлтээс ялган авч үздэг тохиолдолд зөвхөн одоо байгаа хөрөнгө (өр төлбөр)-ийн дахин хянах өдрүүдийн засварлалт нь үр дүнгүй байдал үүсэхэд хүргэдэг. Тооцоолсон дахин хянах өдрүүдийн бүх засварлалт (МЗУ164-р параграфын дагуу хассанаас бусад)-ыг, үүн дотроо одоо байгаа зүйлсийг тайлант үеүдэд хуваарилах аливаа дахин хуваарилалтыг дээрх МЗУ169(б)(ii) параграфын дагуу тайлант үеүдээр тооцоолсон дүнг засварлан өөрчлөхөд, иймээс үр дүнтэй байдлыг хэмжихэд харгалзан оруулна. Дээр дурдсанчлан, үр дүнгүй байдлыг хүлээн зөвшөөрмөгц, байгууллага нь дахин хянах тайлант үе тус бүрээр нийт хөрөнгийн (буюу өр төлбөрийн) шинэ тооцоолол, түүнчлэн үр дүнтэй байдлыг хамгийн сүүлд сорьж шалгаснаас хойш бий болсон шинэ хөрөнгө (өр төлбөр)-ийг тодорхойлох бөгөөд

хейжийн зүйл болох шинэ дүн, хейж хийсэн хувийн жин болох шинэ хувийн жинг тус тус сонгоно. Үр дүнтэй байдлыг сорьж шалгасны дараагийн өдрөөс эхлэн МЗУ169(б) параграфт дурдсан горимуудыг давтан гүйцэтгэнэ.

- МЗУ171. Дахин хянах тайлант үеүдийн анхны хуваарьт тусгагдсан зүйлсийг хүлээгдэж буй урьдчилан төлөлтөөс эрт барагдуулсан, үнэ цэнийн бууралт буюу борлуулалтын үр дүнд данснаас хассан учраас үл хүлээн зөвшөөрч болох юм. Ийм тохиолдолд, тухайн үл хүлээн зөвшөөрсөн зүйлтэй холбоотой бөгөөд МЗУ157(ж) параграфт дурдсан тусдаа мөрийн зүйлд тусгагдсан бодит үнэ цэнийн өөрчлөлтийн дүнг санхүүгийн байдлын тайлангаас хасаж, уг зүйлийн үл хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн олз, гарзад тайлагнана. Энэхүү зорилгын хувьд тухайн үл хүлээн зөвшөөрсөн зүйлийг хуваарилсан, дахин хянах тайлант үеүдийг мэдэх шаардлагатай. Яагаад гэвэл, энэ нь дахин хянах аль тайлант үеэс уг зүйлийг хасах, улмаар МЗУ157(ж) параграфт дурдсан, аль тусдаа мөрийн зүйлээс тэрхүү дүнг хасах эсхэхийг тодорхойлдог. Тухайн зүйлийг үл хүлээн зөвшөөрөх үед энэ нь аль тайлант үед хамаарч байсныг тодорхойлж чадах бол тэрхүү тайлант үеэс түүнийг хасна. Харин ингэж тодорхойлж чадахгүй тохиолдолд хэрэв үл хүлээн зөвшөөрөлт нь хүлээгдэж буй урьдчилан төлөлтөөс эрт барагдуулалтын үр дүн байвал түүнийг хамгийн эхний тайлант үеэс хасна. Харин тухайн зүйлийг борлуулсан эсвэл үнэ цэнэ буурсан бол уг үл хүлээн зөвшөөрсөн зүйлийг агуулах бүх тайлант үеүдэд системчилсэн ба ул үндэслэлтэй сууриар түүнийг хуваарилна.
- МЗУ172. Түүнчлэн, тодорхой тайлант үетэй холбоотой бөгөөд уг тайлант үе дуусахад хараахан үл хүлээн зөвшөөрөөгүй байгаа дүнг тэрхүү тайлант үед ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө (100-р параграфыг үзнэ үү). Жишээлбэл; байгууллага нь дахин хянах гурван тайлант үеэр тухайн зүйлсийг хуваарилдаг гэж үзье. Өмнөх дахин сонголтоор, санхүүгийн байдлын тайлангийн нэг тусдаа мөрийн зүйлд тайлагнасан бодит үнэ цэнийн өөрчлөлт нь 25ТН-ийн хөрөнгө байсан. Энэхүү дүн нь 1, 2, 3 дахь тайлант үеүдэд харгалзан 7ТН, 8ТН, 10ТН байх дүнг илэрхийлнэ. Үүний дараагийн дахин сонголтоор, 1-р тайлант үед хамаарах хөрөнгүүдийг хэрэгжүүлсэн эсвэл өөр тайлант үеүдэд дахин хуваарилсан. Иймээс 7ТН-ийн дүнг санхүүгийн байдлын тайлангаас үл хүлээн зөвшөөрч, ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Одоо 1 ба 2 дахь тайлант үеүдэд хамаарах дүн харгалзан 8ТН ба 10ТН байна. Эдгээр үлдсэн тайлант үеүдийг МЗУ157(ж) параграфт дурдсанчлан, бодит үнэ цэнийн өөрчлөлтийн хувьд шаардлагатай хэмжээгээр дараа нь тохируулна.
- МЗУ173. Өмнөх хоёр параграфын шаардлагуудыг жишээгээр харуулахын тулд байгууллага нь дахин хянах тайлант үе тус бүрд багцын хувийн жингээр хуваарилахаар хөрөнгийн хуваарийг гаргасан гэж үзье. Мөн уг байгууллага нь эхний хоёр тайлант үе тус бүрд 100ТН-ийн хөрөнгийг хуваарилсан гэж үзье. Дахин хянах эхний тайлант үе дуусах үед хүлээгдэж буй болон хүлээгдээгүй урьдчилсан төлбөрүүдийн улмаас 110ТН-ийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрсөн. Энэ тохиолдолд эхний

тайлант үед хамаарах бөгөөд МЗУ157(ж) параграфт дурдсан тусдаа мөрийн зүйлд хамаарах бүх дүнг, түүнчлэн 2 дахь тайлант үед хамаарах 10 хувийн нэмэлт дүнг санхүүгийн байдлын тайлангаас хасна.

МЗУ174. Холбогдох хөрөнгө (эсвэл өр төлбөр)-ийг үл хүлээн зөвшөөрөөгүй боловч дахин хянах тайлант үед хамаарах уг хейж хийсэн дүнг бууруулсан бол тэрхүү бууруулалттай холбоотой бөгөөд МЗУ157(ж) параграфт дурдсан, тусдаа мөрийн зүйлд хамаарах дүнг 104-р параграфын дагуу хорогдуулна.

МЗУ175. УСНББОУС 29-ийн дагуу өмнө нь мөнгөн гүйлгээний хейж гэж тайлагнасан багц хейжийн хувьд байгууллага нь МЗУ157-МЗУ174-р параграфт заасан хандлагыг хэрэглэхийг хүсэж болох юм. Ийм байгууллага нь 112(г) параграфын дагуу хийсэн мөнгөн гүйлгээний хейжийн өмнөх сонголтыг больж, уг параграфт заасан шаардлагуудыг мөрдөнө. Мөн уг байгууллага нь тухайн хейжийг бодит үнэ цэнийн хейж гэж өөрчлөн сонгох ба МЗУ157-МЗУ174-р параграфт заасан хандлагыг дараагийн тайлант үеүдэд гүйцээх горимоор мөрдөнө.

## Хавсралт Б

### Дагалдах үүсмэл хэрэглүүрийн дахин үнэлэлт

*Энэ Хавсралт нь УСНББОУС 29-ийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.*

#### Танилцуулга

- Б1. УСНББОУС 29-ийн 11-р параграфт дагалдах үүсмэл хэрэглүүрийг “холимог (нэгдсэн) хэрэглүүрийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд уг холимог хэрэглүүр нь мөн үүсмэл бус үндсэн гэрээг агуулсан байдаг. Дагалдах үүсмэл хэрэглүүр нь түүний дангаараа байх үетэй ижил төсөөтэй байдлаар тухайн нэгдсэн (холимог) хэрэглүүрийн зарим мөнгөн гүйлгээ хувьсан өөрчлөгдөхөд хүргэдэг” гэж тодорхойлсон.
- Б2. УСНББОУС 29-ийн 12-р параграф нь дагалдах үүсмэл хэрэглүүрийг зөвхөн дараах тохиолдолд үндсэн гэрээнээс салгаж, үүсмэл хэрэглүүр гэж тайлагнахыг шаарддаг:
- (а) Дагалдах үүсмэл хэрэглүүрийн эдийн засгийн шинж чанар ба эрсдэл нь үндсэн гэрээний эдийн засгийн шинж чанар ба эрсдэлтэй нягт холбоотой биш байх;
  - (б) Дагалдах үүсмэл хэрэглүүртэй ижил нөхцлөөр авч үзсэн тусдаа хэрэглүүр нь үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолтыг хангадаг; ба
  - (в) Холимог (нэгдсэн) хэрэглүүрийг түүний бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх байдлаар бодит үнэ цэнээр хэмждэггүй байх (өөрөөр хэлбэл, ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөрийг дагалдаж буй үүсмэл хэрэглүүрийг түүнээс салгахгүй).
- Б3. Байгууллага нь гэрээний оролцогч нэг тал анх удаа болсон тохиолдолд тухайн гэрээнд агуулагдаж буй аливаа дагалдах үүсмэл хэрэглүүрийг уг үндсэн гэрээнээс салгаж, энэ Стандартын дагуу үүсмэл хэрэглүүр гэж тайлагнахыг УСНББОУС 29-өөр шаарддаг. Дараах зүйлс хийгдэх эсэхийг энэ Хавсралтанд авч үзнэ:
- (а) Байгууллага нь гэрээний оролцогч нэг тал анх удаа болсон зөвхөн тийм тохиолдолд уг үнэлгээг хийх эсвэл тухайн гэрээний хугацаанд тэрхүү үнэлгээг дахин харгалзан үзэхийг УСНББОУС 29-өөр шаарддаг эсэх.
  - (б) Стандартыг анх удаа мөрдөж буй байгууллага нь тухайн гэрээний оролцогч нэг тал анх удаа болсон тохиолдолд оршин байсан буюу энэ Стандартыг анх удаа мөрдөх үед давамгайлж байсан нөхцөл байдалд үндэслэн өөрийн үнэлгээг хийдэг эсэх.
- Б4. Улсын секторын нэгдэл дэх дагалдах үүсмэл хэрэглүүр бүхий гэрээний олж эзэмшилт буюу тухайн олж эзэмшсэн өдрөөрх тэдгээрийн боломжит

дахин үнэлэлтээс бусад, УСНББОУС 29-ийн цар хүрээнд хамаарах бүх дагалдах үүсмэл хэрэглүүрийн хувьд энэ Хавсралтыг мөрдөнө.

**Дагалдах үүсмэл хэрэглүүрийн дахин үнэлэлтэнд УСНББОУС 29-ийг мөрдөх**

- Б5. Байгууллага нь гэрээний оролцогч нэг тал анх удаа болсон тохиолдолд дагалдах үүсмэл хэрэглүүрийг уг үндсэн гэрээнээс салгаж, үүсмэл хэрэглүүр гэж тайлагнах шаардлагатай эсэхийг үнэлнэ. Доор дурдсанаас бусад тохиолдолд дараагийн тайлант үед дахин үнэлэлт хийхийг хориглодог: (а) гэрээний дагуу шаардах байсан мөнгөн гүйлгээг мэдэгдэхүйц засварлан өөрчлөхөд хүргэх тийм өөрчлөлт уг гэрээний нөхцөлд орсон, эсвэл (б) санхүүгийн хөрөнгийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэсэн ангиллаас хасаж, дахин ангилсан бөгөөд ингэснээр үнэлгээ хийх шаардлагатай болсон. Дагалдах үүсмэл хэрэглүүртэй эсвэл үндсэн гэрээтэй, эсвэл эдгээрийн аль алинтай холбоотой хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн гүйлгээний өөрчлөгдсөн хэмжээ, түүнчлэн тэрхүү өөрчлөлт нь тухайн гэрээний дагуу өмнө хүлээгдэж байсан мөнгөн гүйлгээний хувьд мэдэгдэхүйц хэмжээтэй эсэхийг харгалзан үзсэнээр уг мөнгөн гүйлгээний засвар өөрчлөлт нь мэдэгдэхүйц эсэхийг байгууллага тодорхойлно.
- Б6. Б5-р параграфт заасанчлан, дагалдах үүсмэл хэрэглүүрийг түүний үндсэн гэрээнээс салгах ба санхүүгийн хөрөнгийг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэсэн ангиллаас хасах тийм дахин ангиллын дагуу үүсмэл хэрэглүүр гэж тайлагнах шаардлагатай эсэх үнэлгээг тухайн байгууллага уг гэрээний оролцогч нэг тал анх удаа болсон үед оршин байсан нөхцөл байдалд үндэслэн хийнэ.
- Б7. УСНББОУС 29-ийг анх удаа мөрдөх үедээ байгууллага нь дагалдах үүсмэл хэрэглүүрийг түүний үндсэн гэрээнээс салган тусгаарлаж, үүсмэл хэрэглүүр гэж тайлагнах шаардлагатай эсэхийг тухайн гэрээний оролцогч тал анх болсон өдөр ба Б5-р параграфтаар дахин үнэлэлт хийхийг шаардсан өдрийн аль сүүлд болох өдрөөр оршин байсан нөхцөл байдалд үндэслэн үнэлнэ.

## Хавсралт В

### Гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хейж

*Энэ Хавсралт нь УСНББОУС 29-ийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.*

#### Танилцуулга

- В1. Тайлагнагч олон байгууллагууд нь гадаад үйл ажиллагаанд хөрөнгө оруулсан байдаг (УСНББОУС 4-ийн 10-р параграфт тодорхойлсон). Ийм гадаад үйл ажиллагаа нь хяналтанд буй байгууллага, хараат байгууллага, хамтарсан үйлдвэр эсвэл салбар байж болох юм. Байгууллага нь өөрийн гадаад үйл ажиллагаа нэг бүрийн бүртгэлийн валютыг тухайн үйл ажиллагааны эдийн засгийн анхдагч орчны валют байдлаар тодорхойлохыг УСНББОУС 4-өөр шаардсан байдаг. Гадаад үйл ажиллагааны санхүүгийн байдал ба үр дүнг толилуулгын валютанд хөрвүүлэх үед байгууллага нь уг гадаад үйл ажиллагааг данснаас хасах хүртэл гадаад валютын ханшийн зөрүүг цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрөх шаардлагатай.
- В2. Гадаад үйл ажиллагааны цэвэр хөрөнгө оруулалтыг санхүүгийн тайланд тусгадаг зөвхөн тийм тохиолдолд гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтаас үүссэн гадаад валютын эрсдлийн хейжийн нягтлан бодох бүртгэлийг мөрдөнө. Нэгтгэсэн санхүүгийн тайлан, мөн хараат байгууллага, хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтыг нь өмчийн аргыг ашиглан тайлагнадаг санхүүгийн тайлан, УСНББОУС 37-д тодорхойлсон салбар буюу хамтын үйл ажиллагааг агуулсан санхүүгийн тайлангийн хувьд ийм тохиолдол үүсдэг. Гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтаас үүсэх гадаад валютын эрсдлийн хувьд хейжийн зүйл нь тухайн гадаад үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн дансны үнэтэй тэнцүү эсвэл түүнээс бага дүн бүхий цэвэр хөрөнгө байж болох юм.
- В3. Хейжийн нягтлан бодох бүртгэлийн харилцаанд шалгуур хангах хейжийн зүйл ба шалгуур хангах хейжийн хэрэглүүрийг сонгохыг УСНББОУС 29-өөр шаарддаг. Цэвэр хөрөнгө оруулалтын хейжийн хувьд сонгосон хейжийн харилцаа байгаа бол цэвэр хөрөнгө оруулалтын үр дүнтэй хейж гэж тодорхойлсон хейжийн хэрэглүүрийн олз, гарзыг цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрөх бөгөөд уг гадаад үйл ажиллагааны санхүүгийн байдал ба үр дүнгийн хөрвүүлэлтээс үүсэх гадаад валютын ханшийн зөрүүгийн хамт тусган оруулна.
- В4. Гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтаас үүсэх гадаад валютын эрсдэлд хейж хийдэг ба хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг УСНББОУС 29-ийн дагуу хангахыг хүсэж буй байгууллагын хувьд энэ Хавсралтыг мөрдөнө. Хейжийн нягтлан бодох бүртгэлийн бусад төрлүүдэд үүнийг адилтган хэрэглэж болохгүй. Хяналт

тавигч байгууллагатай адилтгах тийм байгууллага, түүнчлэн нэгтгэсэн санхүүгийн тайлан байдлаар уг гадаад үйл ажиллагааны цэвэр хөрөнгө оруулалтыг тусгадаг санхүүгийн тайланд энэ Хавсралт хамаарна. Хяналт тавигч байгууллага гэсэн бүх хэллэг нь хамтарсан үйлдвэр, хараат байгууллага, салбар гэх мэт гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалт бүхий байгууллагад мөн адил хамаарна.

B5. Энэ хавсралт нь дараах зүйлсийн талаархи заавар удирамжаар хангана:

- (a) Олон гадаад үйл ажиллагаа бүхий байгууллага нь олон тооны гадаад валютын эрсдэлд өртөж болно гэдгийг харгалзан үзвэл гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хейжийн хувьд хейж хийсэн эрсдлийн шалгуурыг хангах гадаад валютын эрсдлийг тодорхойлох. Энэ нь ялангуяа доорх зүйлсийг харгалзан үзнэ:
- (i) Хяналт тавигч байгууллага нь уг хяналт тавигч байгууллага ба түүний гадаад үйл ажиллагааны бүртгэлийн валютуудын хоорондох зөрүүгээс үүсэх зөвхөн гадаад валютын ханшийн зөрүүг хейж хийсэн эрсдэл гэж сонгож болох эсэх, эсвэл тухайн байгууллага нь хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн толилуулгын валют ба гадаад үйл ажиллагааны бүртгэлийн валютуудын хоорондох зөрүүгээс үүсэх гадаад валютын ханшийн зөрүүг хейж хийсэн эрсдэл гэж бас сонгож болох эсэх; ба
- (ii) Хэрэв хяналт тавигч байгууллага нь гадаад үйл ажиллагааг шууд бусаар эзэмшдэг бол хейж хийсэн эрсдэл нь уг гадаад үйл ажиллагаа ба түүний шууд хяналт тавигч байгууллагын бүртгэлийн валютуудын хоорондох зөрүүгээс үүсэх зөвхөн гадаад валютын ханшийн зөрүүг агуулсан байж болох эсэх, эсвэл тухайн хейж хийсэн эрсдэл нь гадаад үйл ажиллагааны бүртгэлийн валют ба аливаа завсрын буюу эцсийн хяналт тавигч байгууллагын бүртгэлийн валют хоорондох аливаа гадаад валютын ханшийн зөрүүг бас агуулсан байж болох эсэх (өөрөөр хэлбэл, гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтыг завсрын хяналт тавигч байгууллагаар дамжуулан эзэмшиж байх нь уг эцсийн хяналт тавигч байгууллагад учрах эдийн засгийн эрсдэлд нөлөө үзүүлэх эсэх).
- (б) Эдийн засгийн нэгдмэл байгууллага нь хейжийн хэрэглүүрийг эзэмшиж болох бөгөөд дараах асуудлыг тусгайлан харгалзан үзнэ:
- (i) Байгууллага нь үүсмэл эсвэл үүсмэл бус санхүүгийн хэрэглүүрийг (эсвэл үүсмэл ба үүсмэл бус санхүүгийн хэрэглүүрийн хослолыг) гадаад валютын эрсдлийн хейжийн хэрэглүүр гэж сонгохыг УСНББОУС 29-өөр зөвшөөрдөг. Хейжийн хэрэглүүрийн шинж төрөл (үүсмэл ба үүсмэл бус) эсвэл нэгтгэлийн арга нь хейжийн үр дүнтэй байдлын үнэлгээнд нөлөөлөх эсэхийг энэ Хавсралтаар авч үзсэн.

- (ii) Гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтанд хейж хийдэг хейжийн хэрэглүүрийг хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангахын тулд эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээнд эзэмшиж болох тохиолдлыг, өөрөөр хэлбэл, цэвэр хөрөнгө оруулалтандаа хейж хийж буй байгууллага нь уг хейжийн хэрэглүүрийн оролцогч тал байх зөвхөн тийм тохиолдолд шалгуур хангах хейжийн нягтлан бодох бүртгэлийн харилцааг тогтоож болох эсэх, эсвэл тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх аливаа байгууллага нь өөрийн бүртгэлийн валютаас үл хамааран хейжийн хэрэглүүрийг эзэмшиж болох эсэхийг энэ Хавсралтаар бас авч үзнэ.
- (в) Гадаад үйл ажиллагааны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүнгийн хөрвүүлэлтээс үүсэх гадаад валютын ханшийн зөрүү ба цэвэр хөрөнгө оруулалтын үр дүнтэй хейж гэж тодорхойлсон хейжийн хэрэглүүрийн олз, гарзын аль алинтай холбоотойгоор цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрч байсан хуримтлагдсан дүнг тухайн байгууллага нь уг гадаад үйл ажиллагааг данснаас хасах үед шууд хүлээн зөвшөөрөхийг УСНББОУС 4 ба УСНББОУС 29-өөр шаарддаг тул хейжийн хэрэглүүр болон хейжийн зүйлийн аль алины хувьд цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрч байсан олз, гарзаа тэрхүү байгууллага нь ямар дүнгээр ашиг, алдагдалд шууд хүлээн зөвшөөрөхөө хэрхэн тодорхойлдог эсэх. Энэ нь ялангуяа доорх зүйлсийг харгалзан үзнэ:
  - (i) Хейж хийсэн гадаад үйл ажиллагааг данснаас хасах тохиолдолд хейжийн хэрэглүүр ба тухайн гадаад үйл ажиллагааны хувьд уг хяналт тавигч байгууллагын гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцөөс ямар дүнгээр тэрхүү хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх эсэх; ба
  - (ii) Нэгтгэлийн арга нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх дүнг тодорхойлоход нөлөө үзүүлэх эсэх.

### **Гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хейжид УСНББОУС 29-ийг мөрдөх**

*Хейж хийсэн эрсдлийн шинж төрөл ба хейжийн харилцааг сонгож болох тухайн хейжийн зүйлийн дүн*

- B6. Гадаад үйл ажиллагааны бүртгэлийн валют ба хяналт тавигч байгууллагын бүртгэлийн валют хоорондох зөрүүгээс зөвхөн үүсэх гадаад валютын ханшийн зөрүүнд хейжийн нягтлан бодох бүртгэлийг мөрдөж болно.
- B7. Гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтаас үүсэх гадаад валютын эрсдлийн хейжийн хувьд хейжийн зүйл нь тухайн хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь уг гадаад үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн дансны үнэтэй тэнцүү эсвэл түүнээс бага



дүн бүхий цэвэр хөрөнгө байж болно. Хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд хейжийн зүйл гэж сонгож болох гадаад үйл ажиллагааны цэвэр хөрөнгийн дансны үнэ нь уг гадаад үйл ажиллагааны арай доод түвшний аливаа хяналт тавигч байгууллага нь тухайн гадаад үйл ажиллагааны бүх эсвэл зарим цэвэр хөрөнгөнд хейжийн нягтлан бодох бүртгэлийг мөрддөг ба хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд тэрхүү нягтлан бодох бүртгэлийг хөтөлдөг эсэхээс хамаардаг.

- B8. Хейж хийсэн эрсдлийг уг гадаад үйл ажиллагааны бүртгэлийн валют ба тэрхүү гадаад үйл ажиллагааны аливаа хяналт тавигч байгууллагын (шууд, завсрын эсвэл эцсийн хяналт тавигч байгууллагын) бүртгэлийн валют хоорондох зөрүүгээс үүсэх гадаад валютын эрсдэл гэж сонгож болох юм. Цэвэр хөрөнгө оруулалтыг завсрын хяналт тавигч байгууллагаар дамжуулан эзэмших нь уг эцсийн хяналт тавигч байгууллагад учрах гадаад валютын эрсдлээс үүсэх эдийн засгийн эрсдлийн шинж төрөлд нөлөө үзүүлэхгүй.
- B9. Гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтаас үүсэх гадаад валютын эрсдэлд өртөлт нь зөвхөн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг нэг удаа хангаж болох юм. Иймээс эдийн засгийн нэгдмэл байгууллагын доторх нэгээс олон тооны хяналт тавигч байгууллага (жишээлбэл; шууд ба шууд бус хяналт тавигч байгууллагын аль аль) нь нэг эрсдлийн хувьд уг гадаад үйл ажиллагааны цэвэр хөрөнгөнд хейж хийдэг бол зөвхөн нэг хейжийн харилцаа нь эцсийн хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангана. Нэг хяналт тавигч байгууллага өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайланд сонгосон хейжийн харилцааг арай дээд түвшний өөр нэг хяналт тавигч байгууллага нь сонгох шаардлагагүй юм. Гэвч арай дээд түвшний хяналт тавигч байгууллага нь хейжийн харилцааг сонгоогүй бол тэрхүү арай дээд түвшний хяналт тавигч байгууллагын хейжийн нягтлан бодох бүртгэлийг хүлээн зөвшөөрөхийн өмнө уг арай доод түвшний хяналт тавигч байгууллагын мөрддөг хейжийн нягтлан бодох бүртгэлийг буцаах ёстой.

*Хейжийн хэрэглүүрийг эзэмших тохиолдол*

- B10. Гадаад үйл ажиллагаан дахь цэвэр хөрөнгө оруулалтын хейжийн хувьд үүсмэл хэрэглүүр эсвэл үүсмэл бус хэрэглүүрийг (эсвэл үүсмэл ба үүсмэл бус хэрэглүүрийн хослолыг) хейжийн хэрэглүүр гэж сонгож болно. Цэвэр хөрөнгө оруулалтын хейжид хамаарах УСНББОУС 29-ийн 98–р параграфын сонголт, баримтжуулалт, үр дүнтэй байдлын шаардлагууд хангагдах тохиолдолд уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын доторх (өөрөө хейж хийгдэж буй гадаад үйл ажиллагаанаас бусад) байгууллага буюу байгууллагууд нь хейжийн хэрэглүүрийг (хэрэглүүрүүдийг) эзэмшиж болох юм. Ялангуяа эдийн засгийн нэгдмэл байгууллагын янз бүрийн түвшин дэх өөр өөр сонголтын боломжуудаас хамааран тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын хейжийн стратегийг оновчтой баримтжуулвал зохино.

B11. Үр дүнтэй байдлыг үнэлэх зорилгоор, уг хейж хийсэн эрсдлийг хейжийн нягтлан бодох бүртгэлийн баримтжуулалтын дагуу хэмждэг бүртгэлийн валют бүхий хяналт тавигч байгууллагын бүртгэлийн валютыг лавлагаа болгосноор тухайн гадаад валютын ханшийн эрсдлийн хувьд хейжийн хэрэглүүрийн үнэ цэнийн өөрчлөлтийг тооцоолно. Хейжийн нягтлан бодох бүртгэлгүй тохиолдолд үнэ цэнийн нийт өөрчлөлтийг тухайн хейжийн хэрэглүүрийг хэрхэн эзэмшиж байгаагаас хамааран ашиг, алдагдалд эсвэл цэвэр хөрөнгө/өмчид шууд, эсвэл эдгээрийн аль алинд хүлээн зөвшөөрнө. Гэвч хейжийн хэрэглүүрийн үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд эсвэл цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрөх эсэх нь хейжийн үр дүнтэй байдлын үнэлгээнд нөлөөлөхгүй. Хейжийн нягтлан бодох бүртгэлийн мөрдөлтийн нэг хэсэг болгон уг өөрчлөлтийн нийт үр дүнтэй хэсгийг цэвэр хөрөнгө/өмчид шууд тусгана. Хейжийн хэрэглүүр нь үүсмэл хэрэглүүр эсвэл үүсмэл хэрэглүүр эсэх болон нэгтгэлийн арга нь хейжийн үр дүнтэй байдлын үнэлгээнд нөлөө үзүүлэхгүй.

*Хейж хийсэн гадаад үйл ажиллагааны данснаас хасалт*

B12. Хейж хийсэн гадаад үйл ажиллагааг данснаас хассан тохиолдолд уг хейжийн хэрэглүүрийн хувьд тухайн хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцөөс хасаж, ашиг алдагдалд дахин ангилах дүн нь УСНББОУС 29-ийн 113-р параграфтаар тодорхойлохыг шаардсан дүн байна. Энэхүү дүн нь үр дүнтэй хейж гэж тодорхойлсон хейжийн хэрэглүүрт хуримтлагдсан олз буюу гарз байна.


B13. Гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хувьд УСНББОУС 4-ийн 57-р параграфын дагуу уг хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцөөс хасаж, ашиг алдагдалд хүлээн зөвшөөрсөн дүн нь тэрхүү гадаад үйл ажиллагаатай холбоотойгоор тухайн хяналт тавигч байгууллагын гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцөд тусгаж байсан дүн байна. Эцсийн хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд, бүх гадаад үйл ажиллагаатай холбоотойгоор гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцөд хүлээн зөвшөөрөх нийт цэвэр дүнд нэгтгэлийн арга нөлөө үзүүлэхгүй. Гэвч уг эцсийн хяналт тавигч байгууллага нь нэгтгэлийн шууд эсвэл алхам алхамаар нэгтгэх аргыг ашигладаг эсэх нь тэрхүү бие даасан гадаад үйл ажиллагааны хувьд гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцөд тусгах дүнд нөлөөлж болох юм.

B14. Шууд арга гэдэг нь гадаад үйл ажиллагааны санхүүгийн тайланг тухайн эцсийн хяналт тавигч байгууллагын бүртгэлийн валютад шууд хөрвүүлдэг нэгтгэлийн арга юм. Алхам алхамаар арга нь гадаад үйл ажиллагааны санхүүгийн тайланг эхлээд аливаа завсрын хяналт тавигч байгууллагын (байгууллагуудын) бүртгэлийн валютад хөрвүүлэх ба дараа нь уг эцсийн хяналт тавигч байгууллагын бүртгэлийн валютад (хэрэв өөр бол толилуулгын валютад) хөрвүүлдэг нэгтгэлийн арга юм.

- В15. Нэгтгэлийн алхам алхамаар аргыг ашиглах нь хейжийн үр дүнтэй байдлыг тодорхойлоход ашигласнаас өөр дүнг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөхөд хүргэж болох юм. Хэрэв нэгтгэлийн шууд аргыг ашигласан бол үүсэх байсан тухайн гадаад үйл ажиллагаатай холбоотой дүнг тодорхойлсноор энэхүү зөрүүг арилгаж болно. Ийм тохируулга хийхийг УСНББОУС 4-өөр шаардаагүй. Гэвч энэ нь бүх цэвэр хөрөнгө оруулалтын хувьд тууштай мөрдвөл зохих нягтлан бодох бүртгэлийн бодлогын сонголт юм.

**Жишээ**

- В16. Өмнөх параграфын мөрдөлтийг доор дурдсан байгууллагын бүтцийг ашигласнаар дараах жишээнд үлгэрчлэн харуулав. Хэдийгээр хийгдэх сорилыг авч хэлэлцэхгүй боловч бүх тохиолдолд уг дурдсан хейжийн харилцааны үр дүнтэй байдлыг УСНББОУС 29-ийн дагуу сорьж шалгана. Эцсийн хяналт тавигч байгууллага болох “Г” хяналт тавигч байгууллага нь нэгтгэсэн санхүүгийн тайлангаа өөрийн бүртгэлийн валют еврогоор (Евро) толилуулдаг. Хяналтанд буй байгууллага нэг бүрийг, өөрөөр хэлбэл “А”, “Б”, “В” гэсэн хяналтанд буй байгууллагуудыг бүрэн өмчилдөг. “Б” хяналтанд буй байгууллага (бүртгэлийн валют нь фунт стерлинг (Стирлинг)) дахь “Г” хяналт тавигч байгууллагын 500 сая фунт стирлингийн цэвэр хөрөнгө оруулалт нь “В” хяналтанд буй байгууллагад (бүртгэлийн валют нь америк доллар (Доллар)) “Б” хяналтанд буй байгууллагын оруулсан 300 сая ам доллартай тэнцэх 159 сая фунт стирлингийн цэвэр хөрөнгө оруулалтыг агуулсан болно. Өөрөөр хэлбэл, “В” хяналтанд буй байгууллага дахь “Б” хяналтанд буй байгууллагын хөрөнгө оруулалтаас бусад түүний цэвэр хөрөнгө нь 341 сая фунт стирлинг байна.



*Хейжийн харилцааг сонгож болох хейж хийсэн эрсдлийн шинж төрөл (B6-B9-р параграф)*

B17. “Г” хяналт тавигч байгууллага нь хяналтанд буй байгууллагуудын тус тусын бүртгэлийн валют (японы иен (иен), фунт стерлинг, ам доллар) ба евроны хоорондох гадаад валютын ханшийн эрсдлийн хувьд “А”, “Б”, “В” гэсэн хяналтанд буй байгууллага нэг бүр дэх өөрийн цэвэр хөрөнгө оруулалтанд хейж хийж болно. Мөн түүнчлэн, “Г” хяналт тавигч байгууллага нь “Б” хяналтанд буй байгууллага ба “В” хяналтанд буй байгууллагын бүртгэлийн валютуудын хоорондох Доллар/Стерлинг гадаад валютын ханшийн эрсдэлд хейж хийж болно. Өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайландаа, “Б” хяналтанд буй байгууллага нь тэдгээрийн бүртгэлийн валютууд болох ам доллар ба фунт стерлингийн хоорондох гадаад валютын ханшийн эрсдлийн хувьд “В” хяналтанд буй байгууллага дахь цэвэр хөрөнгөндөө хейж хийж болно. Хейжийн хэрэглүүрүүд нь үүсмэл хэрэглүүр биш учраас дараах жишээний хувьд сонгосон эрсдэл нь гадаад валютын спот ханшийн эрсдэл байна. Хэрэв хейжийн хэрэглүүр нь форвард гэрээ бол “Г” хяналт тавигч байгууллага нь гадаад валютын форвард ханшийн эрсдлийг сонгож болно.

*Хейжийн харилцааг сонгож болох хейжийн зүйлийн дүн (B6-B9-р параграф)*

B18. “Г” хяналт тавигч байгууллага нь “В” хяналтанд буй байгууллагад оруулсан өөрийн цэвэр хөрөнгө оруулалтаас үүсэх гадаад валютын ханшийн эрсдлийн хувьд хейж хийхийг хүссэн. “А” хяналтанд буй байгууллага нь 300 сая ам долларын гаднаас авсан зээлтэй гэж үзье. Тайлант үеийн эхэнд “А” хяналтанд буй байгууллагын цэвэр хөрөнгө нь 400,000 сая иен байсан бөгөөд үүнд 300 сая ам долларын гаднын зээл багтаж байна.

B19. Хейжийн зүйл нь “В” хяналтанд буй байгууллагад “Г” хяналт тавигч байгууллагын оруулсан, түүний нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь цэвэр хөрөнгө оруулалтын дансны үнэтэй (300 сая ам доллар) тэнцүү эсвэл түүнээс бага дүн бүхий цэвэр хөрөнгө байж болно. Өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайландаа “Г” хяналт тавигч байгууллага нь “В” хяналтанд буй байгууллагын 300 сая ам долларын цэвэр хөрөнгөнд оруулсан өөрийн цэвэр хөрөнгө оруулалттай холбоотой Евро/Долларын гадаад валютын спот ханшийн эрсдэл байдлаар уг “А” хяналтанд буй байгууллагын 300 сая ам долларын гаднын зээлийг сонгож болно. Энэ тохиолдолд “А” хяналтанд буй байгууллагын 300 сая ам долларын гаднын зээлд хамаарах Евро/Долларын гадаад валютын ханшийн зөрүү ба “В” хяналтанд буй байгууллага дахь 300 сая ам долларын цэвэр хөрөнгө оруулалтанд хамаарах Евро/Долларын гадаад валютын ханшийн зөрүүгийн аль алиныг хейжийн нягтлан бодох бүртгэлийг мөрдсөний дараа уг “Г” хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцөд тусгана.

B20. Хейжийн нягтлан бодох бүртгэл байхгүй үед “А” хяналтанд буй байгууллагын 300 сая ам долларын гаднын зээлд хамаарах

Доллар/Евроны гадаад валютын ханшийн нийт зөрүүг “Г” хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

- Доллар/Иений гадаад валютын спот ханшийн өөрчлөлтийг евронд хөрвүүлж, ашиг, алдагдалд тусгах; ба
- Иен/Евроны гадаад валютын спот ханшийн өөрчлөлтийг цэвэр хөрөнгө/өмчид шууд тусгах.

В19-р параграфт заасан сонголтын оронд, “Г” хяналт тавигч байгууллага нь “В” хяналтанд буй байгууллага ба “Б” хяналтанд буй байгууллагын хоорондох Стирлинг/Доллар-ын гадаад валютын спот ханшийн хейж байдлаар уг “А” хяналтанд буй байгууллага дахь 300 сая ам долларын гаднын зээлийг өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайланд сонгож болно. Энэ тохиолдолд “А” байгууллагын 300 сая ам долларын гаднын зээлд хамаарах Доллар/Евроны гадаад валютын ханшийн нийт зөрүүг “Г” хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

- Стирлинг/Долларын гадаад валютын спот ханшийн өөрчлөлтийг “В” хяналтанд буй байгууллагатай холбоотой гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцөд тусгах;
- Стирлинг/Иений гадаад валютын спот ханшийн өөрчлөлтийг евронд хөрвүүлж, ашиг, алдагдалд тусгах;
- Иен/Евроны гадаад валютын спот ханшийн өөрчлөлтийг цэвэр хөрөнгө/өмчид шууд тусгах.

В21. “Г” хяналт тавигч байгууллага нь уг 300 сая ам долларын гаднын зээлийг өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайландаа Евро/Долларын гадаад валютын спот ханшийн эрсдэл ба Стирлинг/Долларын гадаад валютын спот ханшийн эрсдлийн аль алины хейж байдлаар сонгож болохгүй. Нэг хейжийн хэрэглүүр нь тухайн нэг сонгосон эрсдэлд зөвхөн нэг удаа хейж хийдэг. “Б” ба “В” хяналтанд буй байгууллагуудаас бүрдэх тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагаас гадна уг хейжийн хэрэглүүрийг эзэмшдэг учраас “Б” хяналтанд буй байгууллага нь өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайландаа хейжийн нягтлан бодох бүртгэлийг мөрдөхгүй.

*Эдийн засгийн нэгдмэл байгууллагын хаана нь хейжийн хэрэглүүрийг эзэмшиж болох вэ (В10 ба В11-р параграф)?*

В22. В20-р параграфт дурдсанчлан, “А” хяналтанд буй байгууллагын 300 сая ам долларын гаднын зээлийн гадаад валютын ханшийн эрсдлийн хувьд үнэ цэнийн нийт өөрчлөлтийг хейжийн нягтлан бодох бүртгэл хэрэглэдэггүй үед “Г” хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд ашиг, алдагдал (Доллар/Иений спот эрсдэл) болон цэвэр хөрөнгө/өмчийн (Евро/Иений спот эрсдэл) аль алинд бүртгэж болно. “Г” хяналт тавигч байгууллагын бүртгэлийн валют еврог хейжийн баримтжуулалтын дагуу “В” хяналтанд буй байгууллагын бүртгэлийн

валют ам доллартай харьцуулан лавлагаа болгосноор хейжийн хэрэглүүр ба хейжийн зүйлийн аль алины үнэ цэнийн өөрчлөлтийг тооцоолж болох учраас В19-р параграфт сонгосон уг хейжийн үр дүнтэй байдлыг үнэлэх зорилгоор хоёр дүнгийн аль алиныг тусган оруулна. Нэгтгэлийн арга (өөрөөр хэлбэл, шууд арга эсвэл алхам алхамаар арга) нь хейжийн үр дүнтэй байдлын үнэлгээнд нөлөө үзүүлэхгүй.

*Гадаад үйл ажиллагааны данснаас хасалтаар ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн дүн (В12 ба В13-р параграф)*

В23. “В” хяналтанд буй байгууллагыг данснаас хассан тохиолдолд “Г” хяналт тавигч байгууллагын гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц (ГВХН)-өөс шилжүүлж, түүний нэгтгэсэн санхүүгийн тайланд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн дүн нь:

(а) “А” хяналтанд буй байгууллагын 300 сая ам долларын гаднын зээлийн хувьд УСНББОУС 29 нь тодорхойлохыг шаардах дүн өөрөөр хэлбэл, хейжийн үр дүнтэй хэсэг байдлаар цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн гадаад валютын ханшийн эрсдлийн хувьд үнэ цэнийн нийт өөрчлөлтийн дүн байна; ба

(б) “В” хяналтанд буй байгууллагад оруулсан 300 сая ам долларын цэвэр хөрөнгө оруулалтын хувьд тухайн байгууллагын нэгтгэлийн аргаар тодорхойлсон дүн байна. Хэрэв “Г” хяналт тавигч байгууллага нь шууд аргыг хэрэглэдэг бол “В” хяналтанд буй байгууллагын хувьд ГВХН-ийг Евро/Долларын гадаад валютын ханшаар шууд тодорхойлно. Хэрэв “Г” хяналт тавигч байгууллага нь алхам алхамаар нэгтгэх аргыг хэрэглэдэг бол Евро/Стирлингийн гадаад валютын ханшийг ашигласнаар “Г” хяналт тавигч байгууллагын бүртгэлийн валютад хөрвүүлсэн уг Стирлинг/Долларын гадаад валютын ханшийг тусгах “Б” хяналтанд буй байгууллагын хүлээн зөвшөөрсөн ГВХН-өөр тэрхүү “В” хяналтанд буй байгууллагын хувьд түүний ГВХН-ийг тодорхойлно. Өмнөх тайлант үеүдэд “Г” хяналт тавигч байгууллага алхам алхамаар нэгтгэх аргыг ашиглаж байсан нь тэрээр “В” хяналтанд буй байгууллагыг данснаас хасах үедээ ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх ГВХН-ийг өөрийн нягтлан бодох бүртгэлийн бодлогоос хамааран шууд аргыг ямагт ашигласан бол хүлээн зөвшөөрөх байсан тийм дүнгээр тодорхойлохыг шаардахгүй эсвэл ингэж тодорхойлоход саад учруулахгүй.

*Нэгээс олон гадаад үйл ажиллагаанд хейж хийх (В7, В9, В11-р параграф)*

В24. “Г” хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд хейж хийж болох эрсдэл нь ямагт түүний бүртгэлийн валют (евро) ба “Б”, “В” хяналтанд буй байгууллагуудын бүртгэлийн валютууд хоорондох эрсдэл байна гэдгийг дараах жишээнд үлгэрчлэн харуулав. Хоёр гадаад үйл ажиллагааны аль алинд хейж хийдэг тохиолдолд хейжийг хэрхэн сонгосноос үл хамааран “Г” хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцөд тусгах үр

дүнтэй хейжийн хамгийн их дүн нь Евро/Долларын эрсдлийн хувьд 300 сая ам доллар, Евро/Стирлингийн эрсдлийн хувьд 341 фунт стирлинг байна. Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн улмаас үнэ цэнэд гарах бусад өөрчлөлтүүдийг “Г” хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн ашиг, алдагдалд тусгана. Мэдээж, “Г” хяналт тавигч байгууллага нь зөвхөн Доллар/Стирлингийн гадаад валютын спот ханшийн өөрчлөлтийн хувьд 300 сая ам долларыг эсвэл зөвхөн Стирлинг/Евроны гадаад валютын спот ханшийн өөрчлөлтийн хувьд 500 сая фунт стирлингийг сонгох боломжтой юм.

**“Г” байгууллага нь ам долларын болон фунт стирлингийн аль алины хейжийн хэрэглүүрийг эзэмших**

B25. “Г” хяналт тавигч байгууллага нь “Б” хяналтанд буй байгууллагад оруулсан цэвэр хөрөнгө оруулалт, түүнчлэн “В” хяналтанд буй байгууллагад оруулсан хөрөнгө оруулалттай холбоотойгоор гадаад валютын ханшийн эрсдэлдээ хейж хийхийг хүсэж болох юм. “Г” хяналт тавигч байгууллага нь “Б” ба “В” хяналтанд буй байгууллагад оруулсан өөрийн цэвэр хөрөнгө оруулалтын хейж гэж сонгож болох ам доллар болон фунт стирлингээр илэрхийлэгдсэн зохих хейжийн хэрэглүүрүүдийг эзэмшдэг гэж үзье. Өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайландаа “Г” хяналт тавигч байгууллагын хейж болох сонголтуудад дараах зүйлс хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй:

(а) “Г” хяналт тавигч байгууллага ба “В” хяналтанд буй байгууллагын хоорондох гадаад валютын (Евро/Доллар) спот ханшийн эрсдлийн хувьд “В” хяналтанд буй байгууллагад оруулсан 300 сая ам долларын цэвэр хөрөнгө оруулалтын хейж гэж сонгосон 300 сая ам долларын хейжийн хэрэглүүр, түүнчлэн “Г” хяналт тавигч байгууллага ба “Б” хяналтанд буй байгууллагын хоорондох гадаад валютын (Евро/Стирлинг) спот ханшийн эрсдлийн хувьд “Б” хяналтанд буй байгууллагад оруулсан 341 сая фунт стирлингийн цэвэр хөрөнгө оруулалтын хейж гэж сонгосон 341 сая фунт стирлинг хүртэлх хейжийн хэрэглүүр.

(б) “Б” хяналтанд буй байгууллага ба “В” хяналтанд буй байгууллагын хоорондох гадаад валютын (Стирлинг/Доллар) спот ханшийн эрсдлийн хувьд “В” хяналтанд буй байгууллагад оруулсан 300 сая ам долларын цэвэр хөрөнгө оруулалтын хейж гэж сонгосон 300 сая ам долларын хейжийн хэрэглүүр, түүнчлэн “Г” хяналт тавигч байгууллага ба “Б” хяналтанд буй байгууллагын хоорондох гадаад валютын (Евро/Стирлинг) спот ханшийн эрсдлийн хувьд “Б” хяналтанд буй байгууллагад оруулсан 500 сая фунт стирлингийн цэвэр хөрөнгө оруулалтын хейж гэж сонгосон 500 сая фунт стирлинг хүртэлх хейжийн хэрэглүүр.

B26. “В” хяналтанд буй байгууллагад оруулсан “Г” хяналт тавигч байгууллагын цэвэр хөрөнгө оруулалтаас үүсэх Евро/Долларын эрсдэл нь “Б” хяналтанд буй байгууллагад “Г” хяналт тавигч байгууллагын оруулсан цэвэр хөрөнгө оруулалтаас үүсэх Евро/Стирлингийн эрсдлээс өөр байна.

Гэвч В25(а) параграфт дурдсан тохиолдолд “Г” хяналт тавигч байгууллага нь өөрийн эзэмшиж буй ам долларын хейжийн хэрэглүүрийг сонгосноор “В” хяналтанд буй байгууллагад оруулсан хөрөнгө оруулалтаа Евро/Долларын эрсдлээс бүрэн хамгаалж, аль хэдийн хейж хийсэн байна. Хэрэв “Г” хяналт тавигч байгууллага нь өөрийн эзэмшиж буй Стирлингийн хэрэглүүрийг “Б” хяналтанд буй байгууллагад оруулсан 500 сая фунт стирлингийн цэвэр хөрөнгө оруулалтын хейж гэж бас сонговол “В” хяналтанд буй байгууллагад оруулсан түүний ам долларын цэвэр хөрөнгө оруулалттай тэнцүү дүн бүхий фунт стирлингийг илэрхийлэх 159 сая фунт стирлингийн цэвэр хөрөнгө оруулатыг “Г” хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд Стирлинг/Евроны эрсдлийн хувьд хоёр удаа хейж хийхэд хүргэх юм.

- В27. В25(б) параграфт дурдсан тохиолдолд, хэрэв “Г” хяналт тавигч байгууллага нь уг хейж хийсэн эрсдлийг “Б” хяналтанд буй байгууллага ба “В” хяналтанд буй байгууллагын хоорондох гадаад валютын (Стирлинг/Доллар) спот ханшийн эрсдэл гэж сонгосон бол түүний 300 сая ам долларын хейжийн хэрэглүүрийн үнэ цэнийн өөрчлөлтийн зөвхөн Стирлинг/Долларын хэсгийг “В” хяналтанд буй байгууллагад хамааралтай “Г” хяналт тавигч байгууллагын гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцөд тусгана. Уг өөрчлөлтийн үлдэх хэсгийг (159 сая фунт стирлингэд хамаарах Стирлинг/Евроны өөрчлөлттэй тэнцүү дүнг) В20-р параграфт заасанчлан, “Г” хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн ашиг, алдагдалд тусгана. “Б” болон “В” хяналтанд буй байгууллагуудын хоорондох Доллар/Стирлингийн эрсдлийн сонголтонд Стирлинг/Евроны эрсдэл хамаарахгүй учраас “Г” хяналт тавигч байгууллага нь “Г” хяналт тавигч байгууллага ба “Б” хяналтанд буй байгууллагын хоорондох гадаад валютын (Стирлинг/Евро) спот ханшийн эрсдлийн хувьд “Б” хяналтанд буй байгууллагад оруулсан 500 сая фунт стирлинг хүртэлх өөрийн цэвэр хөрөнгө оруулалтыг бас сонгох боломжтой байна.

**“Б” байгууллага нь ам долларын хейжийн хэрэглүүрийг эзэмших**

- В28. “Б” хяналтанд буй байгууллага нь 300 сая ам долларын гаднын зээлтэй бөгөөд уг зээлийн мөнгөн орлогыг фунт стерлингээр илэрхийлэгдсэн байгууллага хоорондын зээл байдлаар “Г” хяналт тавигч байгууллагад шилжүүлсэн гэж үзье. Хөрөнгө ба өр төлбөрийн аль аль нь 159 сая фунт стерлингээр нэмэгдсэн тул “Б” хяналтанд буй байгууллагын цэвэр хөрөнгө өөрчлөгдөхгүй. “Б” хяналтанд буй байгууллага нь “В” хяналтанд буй байгууллагад оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын Стирлинг/Долларын эрсдлийн хейж байдлаар уг гаднын зээлийг өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайландаа сонгож болох юм. “Г” хяналт тавигч байгууллага нь Стирлинг/Долларын эрсдлийн хувьд (В9-р параграфыг үзнэ үү) “В” хяналтанд буй байгууллагад оруулсан өөрийн 300 сая ам долларын цэвэр хөрөнгө оруулалтын хейж байдлаар тэрхүү хейжийн хэрэглүүрийн “Б” хяналтанд буй байгууллагын сонголтыг хэвээр хадгалж болох бөгөөд “Г” хяналт тавигч байгууллага нь өөрийн эзэмшдэг Стирлингийн хэрэглүүрийг “Б” хяналтанд буй байгууллагад оруулсан өөрийн 500 сая фунт стирлингийн нийт цэвэр хөрөнгө оруулалтын хейж



гэж сонгож болно. “Б” хяналтанд буй байгууллагын сонгосон эхний хейжийг уг “Б” байгууллагын бүртгэлийн валютыг (фунт стерлинг) лавлагаа болгосноор үнэлнэ, харин “Г” хяналт тавигч байгууллагын сонгосон хоёр дахь хейжийг тэрхүү “Г” байгууллагын бүртгэлийн валютыг (евро) лавлагаа болгосноор үнэлнэ. Энэ тохиолдолд “В” хяналтанд буй байгууллагад “Г” хяналт тавигч байгууллагын оруулсан цэвэр хөрөнгө оруулалтаас үүсэх зөвхөн Стирлинг/Долларын эрсдлийг уг “Г” хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд Евро/Долларын нийт эрсдлээр биш, харин ам долларын хейжийн хэрэглүүрээр хамгаалж, хейж хийсэн байна. Иймээс “Б” хяналтанд буй байгууллагад “Г” хяналт тавигч байгууллагын оруулсан 500 сая фунт стерлингийн цэвэр хөрөнгө оруулалтаас үүсэх Евро/Долларын нийт эрсдлийг уг “Г” хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд хамгаалж, хейж хийж болох юм.

В29. Гэхдээ “Б” хяналтанд буй байгууллагад төлөх “Г” хяналт тавигч байгууллагын 159 сая фунт стерлингийн зээлийн өглөгийн тайлагналыг бас харгалзан үзэх ёстой. Хэрэв “Г” хяналт тавигч байгууллагын зээлийн өглөгийг “Б” хяналтанд буй байгууллагад оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын нэг хэсэг байдлаар харгалзан үзэхгүй бол энэ нь УСНББОУС 4-ийн 18-р параграфт заасан нөхцлийг хангахгүй учраас түүний хөрвүүлэлтээс үүсэх гадаад валютын Стирлинг/Евроны ханшийн зөрүүг “Г” хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн ашиг, алдагдалд тусган оруулахаар болох юм. “Б” хяналтанд буй байгууллагад төлөх 159 сая фунт стерлингийн өглөгийг “Г” хяналт тавигч байгууллагын цэвэр хөрөнгө оруулалтын нэг хэсэг байдлаар харгалзан үзвэл тэрхүү цэвэр хөрөнгө оруулалт нь ердөө 341 сая фунт стерлинг болох бөгөөд Стирлинг/Евроны эрсдлийн хувьд “Г” хяналт тавигч байгууллага хейжийн зүйл гэж сонгож болох дүн нь 500 сая фунт стерлингээс 341 сая фунт стерлинг болж, зохих ёсоор буурна.

В30. Хэрэв “Г” хяналт тавигч байгууллага нь “Б” хяналтанд буй байгууллагын сонгосон хейжийн харилцааг буцаасан бол уг “Г” хяналт тавигч байгууллага нь Евро/Долларын эрсдлийн хувьд “В” хяналтанд буй байгууллагад оруулсан өөрийн 300 сая ам долларын цэвэр хөрөнгө оруулалтын хейж байдлаар тэрхүү “Б” хяналтанд буй байгууллагын эзэмшиж буй 300 сая ам долларын гаднын зээлийг сонгож болох бөгөөд өөрийн эзэмшиж буй фунт стирлингийн хейжийн хэрэглүүрийг “Б” хяналтанд буй байгууллагад оруулсан 341 сая фунт стерлинг хүртэлх цэвэр хөрөнгө оруулалтын хейж гэж сонгож болно. Энэ тохиолдолд хоёр хейжийн аль алины үр дүнтэй байдлыг уг “Г” хяналт тавигч байгууллагын бүртгэлийн валют (евро)-ыг лавлагаа болгосноор тооцоолно. Үүний үр дүнд “Б” хяналтанд буй байгууллагын эзэмшиж буй гаднын зээлийн үнэ цэнийн Доллар/Стирлингийн өөрчлөлт ба “Б” хяналтанд буй байгууллагад төлөх “Г” хяналт тавигч байгууллагын зээлийн өглөгийн үнэ цэнийн Стирлинг/Евроны өөрчлөлтийн аль алиныг (нийт дүнгээрээ Доллар/Евроны өөрчлөлттэй тэнцүү) “Г” хяналт тавигч байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцөд тусгана. “Г” хяналт тавигч байгууллага нь “В” хяналтанд буй байгууллагад

## САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

оруулсан өөрийн цэвэр хөрөнгө оруулалтаас үүсэх Евро/Долларын эрсдэлд аль хэдийн бүрэн хейж хийсэн учраас “Б” хяналтанд буй байгууллагад оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын Евро/Стирлингийн эрсдлийн хувьд ердөө 341 сая фунт стирлинг хүртэл дүнд хейж хийж болно.

## Хавсралт Г

### Бусад УСНББОУС-д оруулсан Нэмэлт өөрчлөлт

[Хассан]

## Дүгнэлтийн Үндэслэл

*Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 29-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### Оршил

ДҮ1. УСНББОУС 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*-ийн дүгнэлтүүдэд хүрэхдээ УСНББОУС3-ийн харгалзан үзсэн зүйлсийг энэхүү Дүгнэлтийн Үндэслэлд нэгтгэн товчоолсон. Энэхүү Стандарт нь НББОУС3-өөс гаргасан НББОУС 39, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*-д үндэслэсэн тул УСНББОУС 29 нь НББОУС 39-ийн үндсэн шаардлагуудаас гажих зөвхөн тэдгээр талбаруудыг энэ Дүгнэлтийн Үндэслэлд тусган илэрхийлсэн.

ДҮ2. Санхүүгийн хэрэглүүрийн талаархи энэхүү төсөл нь УСНББОУС-ыг СТОУС-тай нийцүүлэхийг эрмэлзсэн УСНББОУС3-ийн нийцүүлэлтийн хөтөлбөрийн нэг хэсэг болно. Улсын сектортой холбоотой учраас НББОУС 39-д авч үздэггүй санхүүгийн хэрэглүүрийн бусад төлөв байдлууд байдаг гэдгийг УСНББОУС3 тэмдэглэсэн. Тэдгээр төлөв байдлуудыг УСНББОУС3-ийн ирээдүйн төслүүдээр авч үзэх болно. Тухайлбал; дараах зүйлсийг ирээдүйн төслүүдээр авч хэлэлцэхийг шаардана гэж УСНББОУС3 мэдэгдсэн:

- Төв банкны хийсэн зарим ажил гүйлгээ; ба
- Мөн чанарын хувьд санхүүгийн хэрэглүүртэй төсөөтэй ба эдийн засгийн ижил үр нөлөөтэй боловч гэрээний шинж төрөлгүй хэлцлээс үүсдэг авлага ба өглөг.

ДҮ3. Энэ Стандартыг боловсруулахдаа, УСНББОУС3 нь одоо байгаа УСНББОУС-уудтай нийцэх тохиолдолд НББОУС 39-ийн одоогийн текстийг тэр хэвээр хадгалах ба улсын секторын зарим тусгай асуудлуудыг нэмэлт мөрдөх заавар удирдамжаар дамжуулан зохицуулахыг зөвшөөрсөн.

ДҮ4. 2007 оны 9 дүгээр сард НББОУС3 нь НББОУС 1, *Санхүүгийн Тайлангийн Толилуулга*-ын Нэмэлт өөрчлөлтийг гаргасан бөгөөд ингэснээр санхүүгийн тайлангийн толилуулгад “дэлгэрэнгүй орлого”-ыг оруулсан. УСНББОУС3 нь НББОУС 1-д санал болгосон бусад зарим нэмэлт өөрчлөлтийн хамтаар дэлгэрэнгүй орлогыг хараахан авч хэлэлцээгүй байгаа тул тэдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг УСНББОУС 29-д тусган оруулаагүй. 2008 оны 12 дугаар сарын 31-нд хэвлэн нийтэлсэн НББОУС 39-ийн текст, үүн дотроо өөрийн сайжруулалтын төслийн нэг хэсэг байдлаар 2009 оны 4 дүгээр сард НББОУС 39-д НББОУС3-ийн оруулсан зарим нэмэлт өөрчлөлтүүдийг УСНББОУС 29-ийн текстэнд тусган оруулсан. СТОУС 9, *Санхүүгийн Хэрэглүүр*-ийг 2009 оны 11 дүгээр сард гаргасан гэдгийг УСНББОУС3 мэдэгдсэн. НББОУС3 нь НББОУС 39-д цаашид мэдэгдэхүйц засвар өөрчлөлт оруулахаар төлөвлөж байгаа гэдгийг УСНББОУС3 бас хүлээн зөвшөөрсөн. Иймээс УСНББОУС3 нь

санхүүгийн хэрэглүүрт тавигдах НББОУСЗ-ийн шаардлагуудад орох аливаа засвар өөрчлөлтүүдийг өөрийн ирээдүйн төслийн нэг хэсэг байдлаар авч үзэхээр шийдвэрлэсэн.<sup>17</sup>

### Цар хүрээ

ДҮ5. Хөрөнгө ба өр төлбөр нь арилжааны бус гэрээний орлогын ажил гүйлгээнээс үүсэж болох юм. Арилжааны бус орлогын ажил гүйлгээнээс үүсэж буй хөрөнгө, өр төлбөрийн анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийг УСНББОУС 23, *Арилжааны Бус Ажил Гүйлгээний Орлого (Татвар ба Шилжүүлэг)*-д авч үздэг. УСНББОУС 23 нь эдгээр хөрөнгө, өр төлбөрийн дараагийн тайлант үеийн хэмжилт буюу үл хүлээн зөвшөөрөлтөд хамаарах шаардлагууд болон заавар удирдамжаар хангадаггүй. Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангадаг арилжааны бус орлогын ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгө, өр төлбөрийн хувьд энэ Стандарт ба УСНББОУС 23-ын хоорондох уядаа холбоог УСНББОУСЗ харгалзан үзсэн.

ДҮ6. Арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн хөрөнгө нь санхүүгийн хөрөнгө бол байгууллага нь дараах байдлаар тусгана гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн:

- Тухайн хөрөнгийг УСНББОУС 23-ыг ашигласнаар анх хүлээн зөвшөөрнө; ба
- Тухайн хөрөнгийг УСНББОУС 23-ыг ашигласнаар анх хэмжих бөгөөд тэрхүү хөрөнгийг олж эзэмшихийн тулд гаргасан аливаа ажил гүйлгээний зардлын хувьд тохиромжтой арга хандлагыг тодорхойлохын тулд энэ Стандартын шаардлагуудыг харгалзан үзнэ.

УСНББОУС 23 нь арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн хөрөнгийн хувьд дараагийн тайлант үеийн хэмжилт буюу үл хүлээн зөвшөөрөлтийн шаардлагуудыг заагаагүй тул тэдгээр хөрөнгө нь санхүүгийн хөрөнгө бол энэ Стандартыг мөрдөнө.

ДҮ7. УСНББОУС 23-д заасан нөөцийн шилжүүлэлтэнд тавигдах нөхцлүүдээс үүссэн өр төлбөр нь анх хүлээн зөвшөөрөх үед санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг ихэвчлэн хангадаггүй учраас (УСНББОУС 28-ыг үзнэ үү) тэдгээр өр төлбөрийг уг УСНББОУС-ыг ашиглан анх хүлээн зөвшөөрч, анх хэмжинэ гэдгийг УСНББОУСЗ нь өр төлбөрийн хувьд хүлээн зөвшөөрсөн. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, уг өр төлбөр нь санхүүгийн өр төлбөр мөн гэдгийг нөхцөл байдал харуулж байвал байгууллага нь УСНББОУС 23-ын дагуу хүлээн зөвшөөрсөн өр төлбөрийг

---

<sup>17</sup> 2015 оны 01 дүгээр сард УСНББОУСЗ нь хөрөнгө оруулалтын байгууллагууд гэсэн ойлголт ухагдахууныг УСНББОУС 35-д оруулсан бөгөөд тэрхүү Стандартад тодорхойлсончлон, хөрөнгө оруулалттай холбоотой үйлчилгээ буюу үйл ажиллагаа явуулдагаас бусад, хяналтанд буй байгууллагууд дахь өөрийн хөрөнгө оруулалтыг ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжихийг тэдгээр хөрөнгө оруулалтын байгууллагуудаас шаардсан.

үл хүлээн зөвшөөрөх ба санхүүгийн өр төлбөрийг энэ Стандартын дагуу хүлээн зөвшөөрөх хэрэгтэй эсэхийг үнэлнэ.

ДҮ8. Арилжааны бус орлогын ажил гүйлгээнээс үүсдэг бусад өр төлбөр, тухайлбал, хөрөнгийн ашиглалтанд тавигдах хязгаарлалтанд үндэслэсэн нөөцийн буцаалт нь санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангаж байвал түүнийг энэ Стандартын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжинэ гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн.

#### **Анхны хэмжилт**

ДҮ9. Арилжааны бус ажил гүйлгээгээр дамжуулан олж эзэмшсэн бөгөөд санхүүгийн хөрөнгийн тодорхойлолтыг бас хангадаг хөрөнгүүдийн хувьд УСНББОУС 23 ба энэ Стандартын хооронд уялдаа холбоо байна гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн. УСНББОУС 23 нь арилжааны бус орлогын ажил гүйлгээгээр олж эзэмшсэн хөрөнгийг эхлээд түүний бодит үнэ цэнээр хэмжихийг шаарддаг. Хэрэв санхүүгийн хөрөнгийг дараагийн тайлант үед ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэггүй бол тухайн санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнэ дээр ажил гүйлгээний зардлыг нэмсэн дүнгээр анх хэмжихийг энэ Стандартаар шаарддаг. Хэмжилтийн энэхүү хоёр хандлага нь ажил гүйлгээний зардлын тайлагналаас бусад зүйлсийн хувьд хоорондоо ихээхэн нийцтэй байдаг.

ДҮ10. Арилжааны бус ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгийг арилжааны ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгөөс өөр байдлаар хэмжих нь тохиромжгүй гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Иймээс арилжааны бус ажил гүйлгээгээр олж эзэмшсэн хөрөнгийг УСНББОУС 23-ын шаардлагуудын харгалзан эхлээд бодит үнэ цэнээр хэмжих хэрэгтэй боловч тухайн хөрөнгийг олж эзэмшихийн тулд ажил гүйлгээний зардал гаргадаг тохиолдолд энэ Стандартыг бас харгалзан үзвэл зохино гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн.

#### **Хөнгөлөлттэй зээл**

ДҮ11. Байгууллага нь хөнгөлөлттэй зээлийг олгож эсвэл хүлээн авч болно. Хөнгөлөлттэй зээлийн нөхцөл нь зах зээлтэй холбоогүй учраас нягтлан бодох бүртгэлийн тодорхой асуудлуудыг үүсгэдэг. Иймээс хөнгөлөлттэй зээлийн зах зээлийн бус хэсгийг хэрхэн тайлагнахыг УСНББОУСЗ авч үзсэн. Байгууллага нь ажил гүйлгээний мөн чанарыг түүний бүрэлдэхүүн хэсгүүдээр задлан шинжилж, бүрэлдэхүүн нэг бүрийг тусад нь тайлагнахыг УСНББОУСЗ нь СТ 38-д санал болгосон бөгөөд иймээс УСНББОУСЗ нь хөнгөлөлттэй зээлийн зах зээлийн бус хэсгийг дараах байдлаар тайлагнах хэрэгтэй гэж тодорхойлсон:

- Хөнгөлөлттэй зээлийг гаргагч нь зээлийн зах зээлийн бус хэсгийг тэрхүү зээлийг гаргасан тухайн жилд зардал гэж тайлагнах; ба
- Хөнгөлөлттэй зээлийг хүлээн авагч нь уг зээлийн зах зээлийн бус хэсгийг УСНББОУС 23-ын дагуу тайлагнах.

- ДҮ12. СТ 38-д санал өгсөн зарим хүмүүс нь бодит үнэ цэнэ бол хэмжилтийн тохиромжтой суурь гэж үзэхгүй байгаа учраас хөнгөлөлттэй зээлийн хувьд санал болгосон уг арга хандлагатай санал нийлээгүй, харин өөр зарим хүмүүс нь хөнгөлөлттэй зээлийн зах зээлийн бус хэсгийг зардал гэж тайлагнах тухайн санал болгосон арга хандлагатай санал нийлээгүй.
- ДҮ13. Бодит үнэ цэнийг хэмжилтийн суурь гэдэгтэй санал нийлээгүй хүмүүс нь хөнгөлөлттэй зээлийг бодит үнэ цэнээр хэмжих онолын болон практикын хүндрэлтэй талуудыг иш татсан. Онолын түвшинд, улсын секторын байгууллагуудын гаргадаг зарим хөнгөлөлттэй зээл, жишээлбэл жижиг бизнесийн зээл эсвэл сүүлчийн найдвар болох зээлдүүлэгч болохын хувьд өөрийн бүрэн эрхийн хүрээнд засгийн газрын олгодог зээл нь зээлдэгчдийн эрсдлийн түүхээс хамааран хэвийн зах зээлд бэлэн олдоцтой биш байж болно. Хэвийн зах зээлд ердийн байдлаар олдох боломжгүй зээлийн хувьд түүний бодит үнэ цэнийг мэдэж болох боловч тэрхүү бодит үнэ цэнэ нь тухайн ажил гүйлгээний үнэн зөв илэрхийлэл болохгүй гэж тэдгээр санал өгсөн хүмүүс үздэг. Ийм ажил гүйлгээний хэвийн зах зээл оршин байхгүй учраас уг ажил гүйлгээний анхны хэмжилтийн үеийн үнэ нь тухайн зээлийн бодит үнэ цэнийг илэрхийлнэ гэж тэд үздэг. Бодит үнэ цэнийг тодорхойлох практик хүндрэлтэй талуудыг иш татсан тэдгээр санал өгсөн хүмүүс нь ийм хүндрэлүүдийн улмаас тооцоолол ашигласнаар бодит үнэ цэнийг ихэвчлэн тодорхойлдог гэж онцлон тэмдэглэсэн. Тэдний үзэл бодлоор бол ийм тооцоолол ашиглах нь мэдээллийг найдваргүй болгох боломжтой юм. Ийм практик хүндрэлүүдийг даван туулах арга зам болгон тэдгээр санал өгсөн хүмүүс нь бодит үнэ цэнийн өөр хувилбар болгон нэрлэсэн өртөг эсвэл зээлдүүлэгчийн зээлийн хүүний түвшинг хэмжилтийн суурь болгон ашиглахыг санал болгосон.
- ДҮ14. Бодит үнэ цэнийг ашиглах нь хөнгөлөлттэй зээлийн хөнгөлөлтийн элементийг хамгийн үнэн зөв төлөөлөн тодорхойлох боломж олгоно гэсэн үзлийг УСНББОУСЗ баримталдаг. Түүнчлэн, хүүгүй буюу бага хүүтэй олгосон зээл нь улсын секторын хувьд онцгой тохиолдол биш учраас НББОУС 39-д заасан бодит үнэ цэнийн зарчмуудаас гажих улсын секторын тусгай учир шалтгаан байна гэж УСНББОУСЗ үздэггүй. Мөн санхүүгийн хэрэглүүрийн хэмжилтийн талаар, үүн дотроо ажиглах боломжгүй зах зээлийн орцуудыг ашигласан тохиолдолд тусгай тодруулга хийхийг УСНББОУС 30-аар шаарддаг гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Иймээс УСНББОУСЗ нь бодит үнэ цэнийг хөнгөлөлттэй зээлийн хэмжилтийн суурь хэвээр байлгахаар шийдвэрлэсэн.
- ДҮ15. Хөнгөлөлттэй зээлийн зах зээлийн бус хэсгийг зардал болгохтой санал нийлдэггүй тэдгээр хүмүүс нь уг зах зээлийн бус хэсэг бол тусламжийг илэрхийлдэг иймээс эхлээд хөрөнгийг хүлээн зөвшөөрөх ба тэрхүү тусламжийн нөхцөл биелэгдсэн үед эсвэл цаг хугацаатай хувь тэнцүүлсэн сууриар тухайн хөрөнгийг бууруулж, дараагийн тайлант үед зардал болгон хүлээн зөвшөөрөх нь илүү тохиромжтой гэж үздэг. Гэвч зээлийн анх олголт нь эхний өдрөөсөө зээл ба тусламж хэлбэрээр нөөцийг олгох баталгаа болох эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн.

УСНББОУСЗ-ийн үзэл бодлоор бол тухайн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөх үед ийм тусламжийг зардал гэж анх хүлээн зөвшөөрөх нь хариуцлагын зорилгын хувьд хамгийн их ач холбогдолтой мэдээллээр хангадаг.

### **Арилжааны бус ажил гүйлгээгээр гаргасан санхүүгийн баталгаа**

ДҮ16. Улсын секторт санхүүгийн баталгааны гэрээг арилжааны бус ажил гүйлгээгээр байнга гаргадаг, өөрөөр хэлбэл арилжааны зорилгоор биш, харин гаргагчийн өргөн хүрээтэй нийгмийн бодлогын зорилтуудыг ихэвчлэн биелүүлэхийн тулд санхүүгийн баталгааг үнэ төлбөргүй эсвэл нэрлэсэн төлбөртэйгээр гаргадаг гэж УСНББОУСЗ тэмдэглэсэн. Аж ахуйн нэгжүүд нь хувийн хэвшилд бодит үнэ цэнээс бага дүнгээр баталгаа гаргаж болох боловч энэ нь нийтлэг бус бөгөөд хяналт тавигч аж ахуйн нэгж нь өөрийн хяналтанд буй аж ахуйн нэгжийн өмнөөс баталгааг түүний эзэмшигчид гаргах гэх мэт арилжааны учир шалтгаантай байдаг. Улсын секторын хувьд ийм баталгааны зээлийн хамгийн их эрсдэл нь маш том дүнтэй байж болох юм. Идэвхитэй зах зээл оршин байхгүйн улмаас, зарим тохиолдолд зээлийн эрсдлийн хамгийн их хэмжээнээс хамааран хувийн хэвшлийн гаргагч нь баталгааг гаргах боломжгүй учраас ийм баталгааг ихэвчлэн гаргадаг. УСНББОУСЗ нь ийм санхүүгийн баталгааны гэрээний анхны хүлээн зөвшөөрөлтийн болон анхны хүлээн зөвшөөрөлтийн дараах хэмжилтийн хандлагыг харгалзан үзсэн.

ДҮ17. Санхүүгийн баталгааны гэрээг төлбөртэйгээр байгуулсан тохиолдолд уг төлбөрийн дүнг бодит үнэ цэнэ гэж төсөөлөх эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн. НББОУС 39-ийн Мөрдөх Заавар Удирдамжинд “санхүүгийн хэрэглүүрийн анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнэ нь ихэвчлэн уг ажил гүйлгээний үнэ байдаг” гэж заасан. Улсын секторын хувьд санхүүгийн баталгааны гэрээнд хамаарах ажил гүйлгээний үнэ нь ихэнх тохиолдолд бодит үнэ цэнийг тусгадаггүй бөгөөд тийм дүнгээр хүлээн зөвшөөрөх нь гаргагчийн санхүүгийн эрсдлийн талаар буруу ба будлиантай илэрхийлэл болно гэж УСНББОУСЗ үзсэн. Санхүүгийн баталгааны хувьд төлбөртэй тохиолдолд байгууллага нь уг төлбөр арилжааны ажил гүйлгээнээс үүссэн, иймээс бодит үнэ цэнийг төлөөлөн илэрхийлэх эсэхийг тодорхойлох хэрэгтэй гэж УСНББОУСЗ дүгнэсэн. Хэрэв төлбөр нь бодит үнэ цэнийг илэрхийлж байвал байгууллага нь санхүүгийн баталгааг уг төлбөрийн дүнгээр хүлээн зөвшөөрөх бөгөөд дараагийн тайлант үеийн хэмжилт нь УСНББОУС 19, *Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө*-ийн дагуу тодорхойлсон дүн ба анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс тохиромжтой тохиолдолд УСНББОУС 9, *Арилжааны Ажил Гүйлгээний Орлого*-ын дагуу хүлээн зөвшөөрсөн, хуримтлагдсан хорогдуулгыг хассан дүнгийн аль өндөр нь байна. Ажил гүйлгээний үнэ нь бодит үнэ цэнэ биш байх тохиолдолд байгууллага нь төлбөр төлөөгүй байх үетэй ижил байдлаар анхны хүлээн зөвшөөрөлтийн үед түүний хэмжилтийг тодорхойлох шаардлагатай юм.

ДҮ18. Иймээс УСНББОУСЗ нь төлбөргүй эсвэл бодит үнэ цэнээс өөр төлбөртэй гаргасан санхүүгийн баталгааны гэрээний анхны хүлээн зөвшөөрөлтийн



үеийн хэмжилтийг тодорхойлох арга хандлагыг авч үзсэн. УСНББОУСЗ нь төлбөргүй эсвэл бодит үнэ цэнээс өөр төлбөртэй гаргасан санхүүгийн баталгааны гэрээг анх хэмжихэд ашиглаж болох үнэлгээний шатлалыг тодорхойлсон:

- Байгууллага нь санхүүгийн баталгааны гэрээний бодит үнэ цэнийг идэвхитэй зах зээлийн үнийг ажигласнаар тодорхойлж болох эсэхийг үнэлнэ;
- Идэвхитэй зах зээлийн үнийг ажигласнаар түүнийг үнийг тодорхойлох боломжгүй бол байгууллага нь үнэлгээний арга зүйг ашиглана; ба
- Санхүүгийн баталгааны гэрээний хувьд бодит үнэ цэнийг тодорхойлж чадахгүй бол байгууллага нь санхүүгийн баталгааны гэрээг анх хүлээн зөвшөөрөх болон дараагийн тайлант үед УСНББОУС 19-ийн дагуу хэмжинэ.

ДҮ19. Гаргасан санхүүгийн баталгааны гэрээтэй адилтгах буюу ижил төсөөтэй гэрээний идэвхитэй зах зээл оршин байх тохиолдлууд байж болох юм. Ийм тохиолдолд уг идэвхитэй зах зээлийн ажиглалтаар бодит үнэ цэнийг тооцоолох хэрэгтэй. Идэвхитэй зах зээл байхгүй тохиолдолд байгууллага нь УСНББОУС 19-д үндэслэсэн арга хандлагад шууд шилжих шаардлагатай эсэхийг УСНББОУСЗ харгалзан үзсэн. Үнэлгээний олон арга зүй нь маш нарийн цогц бөгөөд МЗУ107, МЗУ108-р параграфт тэмдэглэсэнчлэн, янз бүрийн үр дүнд хүргэж болно гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Ийм арга зүйг боловсруулах өртөг зардал нь мэдээллийн хэрэглэгчдэд олгох өгөөжөөс давж илүү гарна гэж маргадаг. УСНББОУС 19-д үндэслэсэн арга хандлага нь санхүүгийн баталгааны гэрээг байгуулсаны үр дүнд гаргагчид учрах эрсдлийн талаар илүү найдвартай ба ойлгомжтой хэмжүүрээр хангаж болох юм. Байгууллага нь УСНББОУС 19-ийн дагуу өр төлбөрийг хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд нөөцийг зарцуулах магадлал багатай байхаас бусад тохиолдолд тухайн байгууллага нь болзошгүй өр төлбөрийн хувьд УСНББОУС 19-өөр шаардсан тодруулгыг хийнэ гэдгийг УСНББОУСЗ бас мэдэгдсэн. Үнэгүй эсвэл нэрлэсэн төлбөртэйгээр гаргасан санхүүгийн баталгаатай холбоотой эрсдлийн талаар хэрэглэгчдэд олгосон мэдээлэл нь УСНББОУС 30, *Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга*-д заасан, зээлийн эрсдлийн тодруулгыг бас агуулсан байдаг. Эсрэгээр, угаасаа нарийн цогц үнэлгээний арга зүйг боловсруулах актуарч зэрэг экспертийг ашиглахыг шаарддаг УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж* гэх мэт УСНББОУС-ууд одоо байгаа гэдгийг УСНББОУСЗ онцлон тэмдэглэсэн. Идэвхитэй зах зээл байхгүй үед ажиглаж болох зах зээлд үндэслээгүй үнэлгээний арга зүй нь арилжааны бус ажил гүйлгээгээр тухайн гаргагчийн байгуулсан санхүүгийн баталгааны гэрээний хувьд бодит үнэ цэнийг тодорхойлох найдвартай ба ойлгомжтой аргыг бүрдүүлнэ гэдэгт уг байгууллага итгэлтэй байгаа бол ийм үнэлгээний арга зүй ашиглахыг түүнд зөвшөөрөх хэрэгтэй гэж УСНББОУСЗ эцэст нь дүгнэсэн. Зээлийн үл төлөлт ба зээлийн эрсдлийн талаар бэлэн боломжтой мэдээлэл хязгаарлагдмал байх стандарт бус баталгааны хувьд ялангуяа ийм тохиолдол үүсдэг.

**2016 оны 4 дүгээр сард гаргасан, УСНББОУСЗ-ийн УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал-ын үр дүнд УСНББОУС 29-д хийсэн хянан засварлалт**

ДҮ20. УСНББОУСЗ нь 2016 оны 4 дүгээр сард *УСНББОУС-ын Мөрдөгдөх Боломжит Байдал*-ыг гаргасан. Энэхүү тунхаглал нь мөрдөгдөх боломжит байдлын талаархи бүх УСНББОУС дахь хэллэгт нэмэлт өөрчлөлт оруулсан:

- (а) “УҮГ-аас бусад, улсын секторын байгууллагуудад” УСНББОУС-ын мөрдөгдөх боломжит байдлын талаархи стандарт параграфыг Стандарт нэг бүрийн цар хүрээний хэсгээс хасах;
- (б) “УҮГ” нэр томъёог тохиромжтой бол “улсын секторын худалдаа арилжааны байгууллага” нэр томъёогоор сольж орлуулах; ба
- (в) УСНББОУС-ыг мөрдөх улсын секторын байгууллагуудын эерэг тайлбар тодорхойлолтыг хийснээр *Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Оршлын 10-р* параграфт нэмэлт өөрчлөлт оруулах.

Эдгээр өөрчлөлтүүдийн учир шалтгааныг УСНББОУС 1-ийн Дүгнэлтийн Үндэслэлд тусгасан.

## Хэрэгжүүлэх заавар удирдамж

*Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 29-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### Хэсэг А: Цар хүрээ

A.1 *Цэвэр дүнгээр барагдуулах практик: Бараа бүтээгдэхүүнийг худалдан авах форвард гэрээ*

**XYZ байгууллага нь өөрийн хүлээгдэж буй ашиглалтын шаардлагуудын дагуу нэг сая литр газрын тос худалдан авахын тулд тогтмол үнэтэй форвард гэрээг байгуулсан. Уг гэрээ нь арван хоёр сарын дараа тухайн газрын тосыг биетээр хүлээн авах эсвэл газрын тосны бодит үнэ цэнийн өөрчлөлтөнд үндэслэн цэвэр дүнгээр нь мөнгөөр төлөх буюу хүлээн авах байдлаар барагдуулах боломжийг XYZ байгууллагад олгодог. Энэхүү гэрээг үүсмэл хэрэглүүр байдлаар тайлагнах уу?**

Хэдийгээр ийм гэрээ нь үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолтыг хангах боловч түүнийг заавал үүсмэл хэрэглүүр гэж тайлагнах шаардлагагүй юм. Анхны цэвэр хөрөнгө оруулалт байхгүй бөгөөд гэрээ нь газрын тосны үнэд үндэслэдэг ба түүнийг ирээдүйд барагдуулах учраас энэ гэрээ нь үүсмэл хэрэглүүр юм. Гэвч XYZ байгууллага нь барааг хүлээн авснаар тухайн гэрээг барагдуулах санаа зорилготой бөгөөд ижил төсөөтэй гэрээг цэвэр дүнгээр нь мөнгөөр барагдуулж байсан эсвэл газрын тосыг хүлээн авах ба үнийн богино хугацааны хэлбэлзэл буюу дилерийн ашиг олох зорилгоор тэрхүү нийлүүлэлтийн дараа, богино хугацааны дотор түүнийг борлуулдаг түүхэн туршлагагүй бол уг гэрээг УСНББОУС 29-ийн дагуу үүсмэл хэрэглүүр гэж тайлагнахгүй. Харин үүнийг гүйцэтгэлийн гэрээ байдлаар тайлагнана.

A.2 *Санхүүгийн бус хөрөнгийг буцаах опцион*

**XYZ байгууллага нь оффисын барилга өмчилдөг. XYZ байгууллага нь буцаах опционы гэрээг хөрөнгө оруулагчтай байгуулсан бөгөөд энэ нь тухайн барилгыг 150 сая ТН-ээр тэрхүү хөрөнгө оруулагчид буцаан өгөх эрхийг түүнд олгодог. Барилгын одоогийн үнэ цэнэ нь 175 сая ТН байна. Опционы эрхийн хугацаа нь таван жилийн дараа дуусна. Хэрэв опционыг хэрэгжүүлвэл XYZ байгууллагын сонголтын дагуу биетээр хүргэн нийлүүлснээр эсвэл цэвэр дүнгээр нь мөнгөөр уг опционыг барагдуулж болох юм. XYZ байгууллага ба хөрөнгө оруулагчийн аль аль нь энэхүү опционыг хэрхэн тайлагнах вэ?**

XYZ байгууллагын нягтлан бодох бүртгэл нь барагдуулалтын талаархи түүний санаа зорилго ба өмнөх практик туршлагаас хамаарна. Хэдийгээр уг гэрээ нь үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолтыг хангах боловч хэрэв XYZ байгууллага нь өөрийн опционыг хэрэгжүүлж, тухайн барилгыг өгснөөр гэрээг барагдуулах санаа зорилготой бөгөөд цэвэр дүнгээр нь барагдуулж байсан өмнөх туршлагагүй бол үүнийг үүсмэл хэрэглүүр гэж тайлагнахгүй (УСНББОУС 29-ийн 4-р параграф ба УСНББОУС 29-ийн МЗУ22-р параграфыг үзнэ үү).

Харин хөрөнгө оруулагч нь нийлүүлэлт хийхийг шаардах чадвар, боломжгүй учраас өөрийн хүлээгдэж буй худалдан авалт, борлуулалт эсвэл ашиглалтын шаардлагуудыг хангахын тулд опционы гэрээг байгуулсан гэж дүгнэж болохгүй юм (УСНББОУС 29-ийн 6-р параграф). Түүнчлэн, уг опционыг цэвэр дүнгээр нь мөнгөөр барагдуулж болно. Иймээс хөрөнгө оруулагч нь уг гэрээг үүсмэл хэрэглүүр гэж тайлагнах ёстой. Өмнөх практикаас үл хамааран хөрөнгө оруулагчийн санаа зорилго нь нийлүүлэлтээр эсвэл мөнгөөр барагдуулах эсэхэд нөлөө үзүүлэхгүй. Хөрөнгө оруулагч нь опционыг гаргасан бөгөөд ийм опционы гаргагч нь нийлүүлэлт хийхийг шаардах чадвар боломжгүй учраас биетээр барагдуулах эсвэл мөнгөөр барагдуулах сонголтыг опционы эзэмшигч эдэлдэг гаргасан опцион нь УСНББОУС 29-ийн гажих нөхцөл болох хэвийн нийлүүлэлтийн шаардлагыг хэзээ ч хангадаггүй.

Харин энэ гэрээ нь опцион биш, форвард гэрээ байсан ба биет нийлүүлэлтийг шаарддаг бөгөөд тухайн тайлагнагч байгууллага цэвэр дүнгээр нь мөнгөөр барагдуулах эсвэл барилгыг хүлээн хүлээн авах ба үнийн богино хугацааны хэлбэлзэл буюу дилерийн ашиг олох зорилгоор тэрхүү нийлүүлэлтийн дараа, богино хугацааны дотор түүнийг борлуулдаг өмнөх туршлагагүй бол уг гэрээг үүсмэл хэрэглүүр гэж тайлагнахгүй.

## **Хэсэг Б: Тодорхойлолт**

Б.1 *Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт: Үүсмэл хэрэглүүр ба суурь зүйлсийн жишээ*

**Нийтлэг үүсмэл гэрээ ба тодорхойлсон суурь зүйлийн жишээ юу вэ?**

УСНББОУС 29 нь үүсмэл хэрэглүүрийг дараах байдлаар тодорхойлсон:

**Үүсмэл хэрэглүүр гэдэг нь энэ Стандартын цар хүрээнд хамаарах бөгөөд дараах бүх гурван шинж чанар бүхий санхүүгийн хэрэглүүр буюу бусад гэрээ юм:**

- (a) **Тохиролцсон хүүний хувь, санхүүгийн хэрэглүүрийн үнэ, бараа бүтээгдэхүүний үнэ, гадаад валютын ханш, үнийн буюу ханшийн индекс, зээлийн зэрэглэл буюу зээлийн индекс, түүнчлэн уг гэрээний аль нэг талд тусгайлан хамаарахгүй санхүүгийн бус хувьсагч гэх мэт бусад хувьсагчдын (зарим үед ‘суурь зүйл’ гэж нэрлэдэг) өөрчлөлтийн хариу болгон түүний үнэ цэнэ өөрчлөгддөг.**
- (б) **Анхны цэвэр хөрөнгө оруулалт шаарддаггүй эсвэл зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөнд ижил төсөөтэй хариу үзүүлэхээр хүлээгдэж буй бусад төрлийн гэрээний хувьд шаардлагатай дүнгээс бага хэмжээний анхны цэвэр хөрөнгө оруулалт шаарддаг.**
- (в) **Ирээдүйн өдөр барагдуулдаг.**

<b>Гэрээний төрөл</b>	<b>Үнэ тогтоох-барагдуулах үндсэн хувьсагч (суурь хувьсагч)</b>
Хүүний түвшний своп	Хүүний түвшин
Валютын своп (гадаад валютын ханшийн своп)	Валютын ханш
Бараа бүтээгдэхүүний своп	Бараа бүтээгдэхүүний үнэ
Өмчийн своп	Өмчийн үнэ (өөр байгууллагын өмчийн хэрэглүүр)
Зээлийн своп	Зээлийн зэрэглэл, зээлийн индекс буюу зээлийн үнэ
Нийт өгөөжийн своп	Харгалзах хөрөнгө ба хүүний түвшний нийт бодит үнэ цэнэ
Худалдан авсан эсвэл гаргасан сангийн бондын опцион (дуудах эсвэл буцаах)	Хүүний түвшин
Худалдан авсан эсвэл гаргасан валютын опцион (дуудах эсвэл буцаах)	Валютын ханш
Худалдан авсан эсвэл гаргасан бараа бүтээгдэхүүний опцион (дуудах эсвэл буцаах)	Бараа бүтээгдэхүүний үнэ
Худалдан авсан эсвэл гаргасан хувьцааны опцион (дуудах эсвэл буцаах)	Өмчийн үнэ (өөр байгууллагын өмчийн хэрэглүүр)
Засгийн газрын өртэй уялдсан хүүний түвшний фьючерс (сангийн фьючерс)	Хүүний түвшин
Валютын фьючерс	Валютын ханш
Бараа бүтээгдэхүүний фьючерс	Бараа бүтээгдэхүүний үнэ
Засгийн газрын өртэй уялдсан хүүний түвшний форвард (сангийн форвард)	Хүүний түвшин
Валютын форвард	Валютын ханш
Бараа бүтээгдэхүүний форвард	Бараа бүтээгдэхүүний үнэ
Өмчийн форвард	Өмчийн үнэ (өөр байгууллагын өмчийн хэрэглүүр)

УСНББОУС 29-ийн дагуу үүсмэл хэрэглүүрийн шалгуурыг ихэвчлэн хангадаг гэрээнүүдийн жишээг дээрх жагсаалтанд харуулав. Энэхүү жагсаалтанд бүгдийг багтаагаагүй болно. Суурь зүйл бүхий аливаа гэрээ нь үүсмэл хэрэглүүр байж болох юм. Түүнчлэн, хэрэглүүр нь үүсмэл гэрээний тодорхойлолтыг хангадаг боловч тухайлбал; цаг агаарын үүсмэл хэрэглүүр (УСНББОУС 29-ийн МЗУ5-р параграфыг үзнэ үү), бараа бүтээгдэхүүн гэх мэт санхүүгийн бус зүйлийг худалдан авах буюу борлуулах гэрээ (УСНББОУС 29-ийн 4-р параграф ба УСНББОУС 29-ийн МЗУ22-р параграфыг үзнэ үү), байгууллагын өөрийн хувьцаагаар барагдуулах гэрээ (УСНББОУС 28-ын 25-29-р параграфыг үзнэ үү) бол УСНББОУС 29-ийн тусгай заалтуудыг мөрдөж болох юм. Иймээс байгууллага нь үүсмэл хэрэглүүрийн бусад шинж чанарууд байгаа эсэх, түүнчлэн тусгай заалтуудыг мөрдөх эсэхийг тодорхойлохын тулд тухайн гэрээг үнэлэх ёстой.

Б.2 *Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт: Ирээдүйд төлбөрийг барагдуулах, цэвэр эсвэл нийт дүнгээр барагдуулах хүүний түвшний своп*

**Талууд хүүг тус тусдаа төлөх (нийт дүнгээр барагдуулах) эсвэл цэвэр дүнгээр барагдуулах нь хүүний түвшний свопыг УСНББОУС 29-ийн дагуу үүсмэл санхүүгийн хэрэглүүр гэж тодорхойлох эсэхэд нөлөө үзүүлэх үү?**

Үгүй. Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт нь нийт дүнгээр эсвэл цэвэр дүнгээр барагдуулах эсэхээс хамаарахгүй.

Үлгэрчлэн харуулвал: ABC байгууллага нь 8 хувийн тогтмол хүүг төлөх ба улирал тутам шинэчлэн тогтоогдох гурван сарын хугацаатай ЛАЙБОР хүүнд үндэслэсэн хувьсах хүүг хүлээн авахыг түүнээс шаардах хүүний түвшний свопын гэрээг нөгөө талтайгаа (XYZ) байгуулсан. Тогтмол ба хувьсах дүнг 100 сая ТН бүхий нэрлэсэн дүнд үндэслэн тодорхойлдог. ABC ба XYZ байгууллага нь нэрлэсэн дүнг өөрчлөхгүй. ABC байгууллага нь 8 хувь ба гурван сарын хугацаатай ЛАЙБОР-ын хоорондох зөрүүд үндэслэсэн цэвэр мөнгөн дүнг улирал бүр төлнө эсвэл хүлээн авна. Өөр нэг хувилбар нь нийт дүнгээр хийгдэх барагдуулалт байж болох юм.

Уг гэрээний үнэ цэнэ нь суурь хувьсагчийн (ЛАЙБОР) өөрчлөлтөөс хамааран өөрчлөгдөх бөгөөд анхны цэвэр хөрөнгө оруулалтгүй ба ирээдүйд барагдуулах учраас энэ нь цэвэр дүнгээр эсвэл нийт дүнгээр барагдуулах эсэхээс үл хамааран үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолтыг хангана.

Б.3 *Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт: Урьдчилж төлсөн хүүний түвшний своп (Үүсэх үед эсвэл дараа нь урьдчилж төлсөн тогтмол хүүтэй төлбөрийн үүрэг)*

**Хэрэв нэг тал нь тогтмол хүү-төлөх ба хувьсах хүү-хүлээн авах хүүний түвшний свопын дагуу өөрийн үүргийг уг үүссэн өдөр урьдчилж төлсөн бол энэхүү своп нь үүсмэл санхүүгийн хэрэглүүр мөн үү?**

Тийм.

Үлгэрчлэн харуулвал: S байгууллага нь тогтмол хүү төлөх ба хувьсах хүү хүлээн авах 100 сая ТН-ийн нэрлэсэн дүнтэй, таван жилийн хугацаатай, хүүний түвшний свопын гэрээг нөгөө тал болох C байгууллагатай байгуулсан. Уг свопын хувьсах хэсгийн хүүний түвшинг гурван сарын хугацаатай ЛАЙБОР-оор улирал бүр шинэчлэн тогтоодог. Свопын тогтмол хэсгийн хүүний түвшин нь жилийн 10 хувь байна. S байгууллага нь свопын дагуу төлөх өөрийн 50 сая ТН-ийн (100 сая ТН x 10 хувь x 5 жил) тогтмол үүргийг уг үүссэн өдөр зах зээлийн хүүний түвшинг ашиглан дискаунтчилснаар урьдчилж төлсөн бөгөөд гурван сарын хугацаатай ЛАЙБОР-т үндэслэн улирал бүр шинэчлэн тогтоож, 100 сая ТН-ээс тооцох хүүг тухайн свопын хугацаанд хүлээн авах эрхээ хадгалан үлдсэн.

Уг хүүний түвшний свопын анхны цэвэр хөрөнгө оруулалт нь хувьсах хэсгийн дагуу хувьсах хүүг тооцох үндэслэл болох тухайн нэрлэсэн дүнгээс мэдэгдэхүйц бага байна. Энэ гэрээ нь хувьсах хүүтэй бонд гэх мэт зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөнд ижил төсөөтэй хариу үзүүлэхээр хүлээгдэж буй бусад төрлийн гэрээний хувьд шаардлагатай дүнгээс бага хэмжээний анхны цэвэр хөрөнгө

оруулалтыг шаарддаг. Иймээс тухайн гэрээ нь “анхны цэвэр хөрөнгө оруулалтгүй эсвэл зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөнд ижил төсөөтэй хариу үзүүлэхээр хүлээгдэж буй бусад төрлийн гэрээний хувьд шаардлагатай дүнгээс бага хэмжээний анхны цэвэр хөрөнгө оруулалттай” гэсэн УСНББОУС 29-ийн нөхцлийг биелүүлж байна. Хэдийгээр S байгууллага нь ирээдүйн гүйцэтгэлийн үүрэггүй боловч тухайн гэрээний эцсийн барагдуулалт нь ирээдүйд хийгдэх бөгөөд гэрээний үнэ цэнэ нь ЛАЙБОР индексийн өөрчлөлтөөс хамааран өөрчлөгдөнө. Иймээс уг гэрээг үүсмэл гэрээ гэж үзнэ.

**Хэрэв тогтмол хүү төлөх үүргийг анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа урьдчилж төлсөн бол хариулт өөрчлөгдөх үү?**

Хэрэв свопын тогтмол хэсгийг тухайн хугацааны туршид урьдчилж төлсөн бол үүнийг уг одоогийн свопын дуусгавар болголт ба УСНББОУС 29-ийн дагуу үнэлэх шинэ хэрэглүүрийн үүсэлт гэж үзнэ.

Б.4 *Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт: Хувьсах хүү-төлөх ба тогтмол хүү-хүлээн авах урьдчилж төлсөн хүүний түвшний своп*

**Хэрэв нэг тал нь хувьсах хүү-төлөх ба тогтмол хүү-хүлээн авах хүүний түвшний свопын дагуу өөрийн үүргийг уг гэрээ үүссэн өдөр эсвэл дараа урьдчилж төлсөн бол энэхүү своп нь үүсмэл санхүүгийн хэрэглүүр мөн үү?**

Үгүй. Хувьсах хүү-төлөх ба тогтмол хүү-хүлээн авах урьдчилж төлсөн хүүний түвшний своп нь тогтмол мөнгөн гүйлгээ бүхий өрийн хэрэглүүрийн өгөөжтэй зэрэгцүүлэгдэх урьдчилж төлсөн (оруулсан) дүнд үндэслэн өгөөжийг бий болгодог учраас түүнийг уг үүссэн өдөр урьдчилж төлвөл үүсмэл хэрэглүүр болохгүй, харин үүссэний дараа урьдчилж төлвөл цаашид үүсмэл хэрэглүүр байхаа болино. Тухайн урьдчилж төлсөн дүн нь үүсмэл хэрэглүүрийн “анхны цэвэр хөрөнгө оруулалтгүй эсвэл зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөнд ижил төсөөтэй хариу үзүүлэхээр хүлээгдэж буй бусад төрлийн гэрээний хувьд шаардлагатай дүнгээс бага хэмжээний анхны цэвэр хөрөнгө оруулалттай” гэсэн шалгуурыг хангахгүй юм.

Үлгэрчлэн харуулвал: S байгууллага нь хувьсах хүү төлөх ба тогтмол хүү хүлээн авах 100 сая ТН-ийн нэрлэсэн дүнтэй, таван жилийн хугацаатай, хүүний түвшний свопын гэрээг нөгөө тал болох С байгууллагатай байгуулсан. Уг свопын хувьсах хэсгийн хүүний түвшинг гурван сарын хугацаатай ЛАЙБОР-оор улирал бүр шинэчлэн тогтоодог. Свопын дагуу төлөх тогтмол хүүний төлбөрийг уг свопын нэрлэсэн дүнг 10 хувиар үржүүлснээр тооцоолно. Өөрөөр хэлбэл, жилд 10 сая ТН байна. S байгууллага нь свопын хувьсах хэсгийн дагуу хүлээх өөрийн үүргийг уг үүссэн өдөр одоогийн зах зээлийн хүүний түвшнээр урьдчилж төлсөн бөгөөд 100 сая ТН-ээс жилд 10 хувиар тооцогдох тогтмол хүүг хүлээн авах эрхээ хадгалан үлдсэн.

S байгууллага нь свопын нийт хугацааны туршид жил бүр 10 сая ТН хүлээн авна гэдгээ мэдэж байгаа тул уг гэрээний дагуу үүсэх мөнгөн орлогын гүйлгээ нь жил тутам тогтмол тэнцүү төлбөр бүхий санхүүгийн хэрэглүүрийн мөнгөн гүйлгээтэй ижил байна. Бусад бүх зүйл ижил учраас уг гэрээний анхны хөрөнгө оруулалт нь тогтмол тэнцүү төлбөр бүхий бусад санхүүгийн хэрэглүүрийн хөрөнгө оруулалттай

адил байна. Иймээс хувьсах хүү-төлөх ба тогтмол хүү-хүлээн авах хүүний түвшний свопод оруулсан анхны цэвэр хөрөнгө оруулалт нь зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлтөнд ижил хариу үзүүлэх үүсмэл бус гэрээний хувьд шаардагдах хөрөнгө оруулалттай тэнцүү байна. Энэ шалтгааны улмаас уг хэрэглүүр нь УСНББОУС 29-ийн “анхны цэвэр хөрөнгө оруулалтгүй эсвэл зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөнд ижил төсөөтэй хариу үзүүлэхээр хүлээгдэж буй бусад төрлийн гэрээний хувьд шаардлагатай дүнгээс бага хэмжээний анхны цэвэр хөрөнгө оруулалттай” гэсэн шалгуурыг хангахгүй юм. Ийм учраас уг гэрээг УСНББОУС 29-ийн дагуу үүсмэл хэрэглүүр гэж тайлагнахгүй. Хувьсах хүү төлөх үүргийг биелүүлсэнээр S байгууллага нь үнэн хэрэгтээ нөгөө тал болох C байгууллагад зээл олгож байна.

**Б.5** *Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт: Цэвэр дүнгээр тооцох зээл*

**А байгууллага нь таван жилийн хугацаатай, тогтмол хүүтэй зээлийг Б байгууллагад олгосон, харин Б байгууллага нь яг энэ үед таван жилийн хугацаатай, хувьсах хүүтэй, ижил дүнтэй зээлийг А байгууллагад олгожээ. А ба Б байгууллага нь цэвэр дүнгээр тооцох гэрээтэй учраас энэхүү хоёр зээлийг үүсэх үед үндсэн дүнг шилжүүлээгүй. Энэ нь УСНББОУС 29-ийн дагуу үүсмэл хэрэглүүр мөн үү?**

Тийм. Энэ нь үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолтыг хангана (үүнд тухайлбал, суурь хувьсагч байгаа, анхны цэвэр хөрөнгө оруулалтгүй эсвэл зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөнд ижил төсөөтэй хариу үзүүлэхээр хүлээгдэж буй бусад төрлийн гэрээний хувьд шаардлагатай дүнгээс бага хэмжээний анхны цэвэр хөрөнгө оруулалттай ба ирээдүйд барагдуулна). Уг зээлийн гэрээний үр нөлөө нь анхны цэвэр хөрөнгө оруулалтгүй хүүний түвшний свопын гэрээний нөхцөлтэй адил байна. Тухайн ажил гүйлгээ нь мөн чанарын хувьд үүсмэл хэрэглүүр үүсгэх үр дүнтэй тохиолдолд үүсмэл бус ажил гүйлгээг нэгтгэж, үүсмэл хэрэглүүр гэж тайлагнана. Ийм шинжийг илтгэх үзүүлэлтэд дараах зүйлс хамаарна:

- Тэдгээрийг нэг ижил хугацаанд хооронд нь уялдаатай байгуулдаг;
- Тэдгээр нь нөгөө ижил оролцогч нөгөө талтай байдаг;
- Тэдгээр нь нэг ижил эрсдэлтэй холбоотой байдаг; ба
- Ганц ажил гүйлгээгээр мөн хэрэгжүүлэх боломжгүй ажил гүйлгээнүүдийг тус тусад нь салган задлах эдийн засгийн илт тодорхой хэрэгцээ шаардлага буюу бизнесийн бодит зорилгогүй байх.

УСНББОУС 29-ийн 10-р параграфт заасан үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт нь цэвэр дүнгээр барагдуулахыг шаарддаггүй учраас А ба Б байгууллага нь цэвэр дүнгээр тооцох гэрээгүй бол үүнтэй ижил хариулттай байна.

**Б.6** *Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт: Хэрэгжүүлнэ гэж хүлээгдээгүй опцион*

**УСНББОУС 29-ийн 10-р параграфт заасан үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт нь тухайн хэрэглүүрийг “ирээдүйд барагдуулах”-ыг шаарддаг.**



**Тухайлбал; мөнгөн алдагдалтайн улмаас опционыг хэрэгжүүлэхгүй гэж хүлээж байгаа боловч энэ шалгуур хангагдах уу?**

Тийм. Опционыг хэрэгжүүлснээр эсвэл дуусвар хугацаа болсноор барагдуулдаг. Хэдийгээр төлбөрийн нэмэлт солилцоо хийгдэхгүй боловч хугацаа дуусалт нь барагдуулалтын нэг хэлбэр юм.

*Б.7 Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт: Борлуулалтын тоо хэмжээнд үндэслэсэн гадаад валютын гэрээ*

**Бүртгэлийн валют нь Өмнөд Африкийн ранд болох Өмнөд Африкийн XYZ байгууллага нь Мозамбек улсад ам доллараар тооцогдох цахилгааны борлуулдаг. XYZ байгууллага нь ам долларыг тогтмол арилжааны ханшаар рандад хөрвүүлэх гэрээг хөрөнгө оруулалтын банктэй байгуулсан. 6.00 гэсэн тогтмол ханшаар тооцогдох ам долларын хариуд XYZ байгууллага нь Мозамбек улсад хийсэн борлуулалтын тоо хэмжээндээ үндэслэн ранд шилжүүлэхийг уг гэрээгээр шаарддаг. Энэ гэрээ нь үүсмэл хэрэглүүр мөн үү?**

Тийм. Гэрээ нь (гадаад валютын ханш ба борлуулалтын тоо хэмжээ) хоёр суурь хувьсагчтай, анхны цэвэр хөрөнгө оруулалтгүй эсвэл зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөнд ижил төсөөтэй хариу үзүүлэхээр хүлээгдэж буй бусад төрлийн гэрээний хувьд шаардлагатай дүнгээс бага хэмжээний анхны цэвэр хөрөнгө оруулалттай ба төлбөрийн нөхцөлтэй. УСНББОУС 29 нь борлуулалтын тоо хэмжээнд үндэслэсэн үүсмэл хэрэглүүрийг өөрийн цар хүрээнээс хасдаггүй.

*Б.8 Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт: Урьдчилж төлсөн форвард*

**Байгууллага нь нэг жилийн дараах форвард үнээр хувьцаа худалдан авах форвард гэрээг байгуулсан. Уг гэрээ үүссэн өдөр байгууллага нь тухайн хувьцааны одоогийн үнэд үндэслэн урьдчилж төлсөн. Энэхүү форвард гэрээ нь үүсмэл хэрэглүүр мөн үү?**

Үгүй. Форвард гэрээ нь үүсмэл хэрэглүүрийн “анхны цэвэр хөрөнгө оруулалтгүй эсвэл зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөнд ижил төсөөтэй хариу үзүүлэхээр хүлээгдэж буй бусад төрлийн гэрээний хувьд шаардлагатай дүнгээс бага хэмжээний анхны цэвэр хөрөнгө оруулалттай” гэсэн шалгуурыг хангахгүй юм.

Үлгэрчлэн харуулвал: XYZ байгууллага нь нэг жилийн дараа нэг сая “Т” энгийн хувьцааг худалдан авахын тулд форвард гэрээ байгуулсан. “Т” хувьцааны одоогийн зах зээлийн үнэ нь нэгжийн 50ТН байна; “Т” хувьцааны нэг жилийн форвард үнэ нь нэгж хувьцаанд 55ТН байсан. XYZ байгууллага нь гэрээ үүсэх үед 50 сая ТН-ийн дүн бүхий форвард гэрээг урьдчилан төлөх шаардлагатай. 50 сая ТН-ийн форвард гэрээний анхны хөрөнгө оруулалт нь нэг сая ширхэг хувьцаа гэсэн суурь зүйлийг түүний нэгж хувьцааны 55ТН-ийн форвард үнээр үржүүлсэн уг төсөөлсөн дүнгээс, өөрөөр хэлбэл 55 сая ТН-ээс бага байна. Гэвч “Т” хувьцааг анх үүссэн өдөр уг 50ТН-ээр худалдан авч болох учраас анхны цэвэр хөрөнгө оруулалт нь зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөнд ижил төсөөтэй хариу үзүүлэхээр хүлээгдэж буй бусад төрлийн гэрээний хувьд шаардлагатай хөрөнгө оруулалттай ойролцоо дүнтэй байна. Иймээс уг урьдчилж төлсөн форвард гэрээ нь үүсмэл хэрэглүүрийн анхны цэвэр хөрөнгө оруулалтын шалгуурыг хангахгүй.

Б.9 *Үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолт: Анхны цэвэр хөрөнгө оруулалт*

**Фьючерс гэрээ, бирж дээр арилжаалдаг гаргасан опцион гэх мэт олон үүсмэл хэрэглүүр нь маржин данстай<sup>18</sup> байхыг шаарддаг. Уг маржин данс нь анхны цэвэр хөрөнгө оруулалтын нэг хэсэг мөн үү?**

Үгүй. Маржин данс нь үүсмэл хэрэглүүрт оруулсан анхны цэвэр хөрөнгө оруулалтын нэг хэсэг биш юм. Маржин данс нь оролцогч нөгөө тал буюу клирингийн төвийн барьцаа хэлбэртэй байх бөгөөд бэлэн мөнгө, үнэт цаас буюу бусад тусгайлан заасан хөрөнгө, ихэвчлэн хөрвөх хөрөнгө хэлбэртэй байж болно. Маржин данс нь тусдаа тайлагнах тусдаа хөрөнгө юм.

Б.10 *Худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэдгийн тодорхойлолт: Богино хугацаанд ашиг олох сүүлийн үеийн бодит хэв маяг бүхий багц*

**Худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолт нь “хэрэв энэ нь ... хамтад нь удирдан зохицуулдаг, тодорхойлсон санхүүгийн хэрэглүүрийн багцын нэг хэсэг бөгөөд богино хугацаанд ашиг олох сүүлийн үеийн бодит хэв маягийн нотолгоо байгаа бол санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж ангилна” гэж заасан. Энэхүү тодорхойлолтыг мөрдөх зорилгын хувьд “багц” гэж юу вэ?**

Хэдийгээр “багц” гэсэн нэр томъёог УСНББОУС 29-д илт тодорхой тодорхойлоогүй боловч түүнийг ашиглаж буй агуулгын хувьд багц нь тухайн бүлгийн нэгэн хэсэг байдлаар удирдан зохицуулдаг санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн бүлэг юм (УСНББОУС 29-ийн 10-р параграф). Санхүүгийн хэрэглүүрээс богино хугацаанд ашиг олох сүүлийн үеийн бодит хэв маягийг ийм багцад тусган оруулсан гэсэн нотолгоо байгаа бол хэдийгээр бие даасан санхүүгийн хэрэглүүрийг үнэн хэрэгтээ илүү урт хугацаагаар эзэмшиж болох боловч тэдгээр санхүүгийн хэрэглүүр нь худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэсэн шалгуурыг хангана.

Б.11 *Худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэдгийн тодорхойлолт: Багцын тэнцвэржүүлэлт*

**А байгууллага нь өр ба өмчийн хэрэглүүрүүдийн хөрөнгө оруулалтын багцтай. Багцын өмчийн эрсдлийг нийт багцын үнэ цэнийн 30-50 хувийн хооронд хязгаарлах хэрэгтэй гэж уг багцын удирдлагын баримтжуулсан зааварт тусгайлан заасан. Өмчийн болон өрийн хэрэглүүрүүдийг худалдан авах ба борлуулах замаар уг сонгосон зааврын хүрээнд багцыг тэнцвэржүүлэх бүрэн эрхийг тухайн багцын хөрөнгө оруулалтын менежерт олгодог. А байгууллага нь тэдгээр хэрэглүүрийг борлуулах боломжтой гэж ангилахыг зөвшөөрөх үү?**

---

<sup>18</sup> Margin account-Маржин данс гэдэг нь хувьцаа буюу бусад санхүүгийн бүтээгдэхүүнийг худалдан авахад зориулж, үйлчлүүлэгч нартаа мөнгө зээлдүүлдэг брокерын данс юм. Ред.Ч.Д.

Энэ нь А байгууллагын санаа зорилго ба өмнөх туршлагаас хамаарна. Хэрэв багцын эрсдлийг тэнцвэржүүлэхийн тулд хэрэглүүрүүдийг худалдан авах ба борлуулахыг уг багцын менежерт зөвшөөрдөг боловч худалдан арилжих санаа зорилгогүй бөгөөд богино хугацаанд ашиг олох зорилгоор арилжиж байсан өмнөх туршлага байхгүй бол тухайн хэрэглүүрийг борлуулах боломжтой гэж ангилж болно. Хэрэв багцын менежер нь богино хугацаанд ашиг олох зорилгоор хэрэглүүрийг идэвхитэй худалдан авч, борлуулдаг бол тухайн багц дахь санхүүгийн хэрэглүүрүүдийг худалдан арилжих зорилгоор эзэмшиж буй гэж ангилна.

*Б.12 Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгийн тодорхойлолт: Индекс тэй уялдсан үндсэн дүн*

**А байгууллага нь 10ТН-ийн анхны гаргалтын үнэтэй бөгөөд таван жилийн хугацаатай, өмчийн индекс тэй уялдсан өрийн бичгийг уг худалдан авалтын өдөр 12ТН-ийн зах зээлийн үнээр худалдан авсан. Уг өрийн бичиг нь дуусгавар болох хугацаанаас өмнө хүү төлдөггүй. Дуусгавар болох үед уг өрийн бичиг нь 10ТН-ийн анхны гаргалтын үнэ, түүнчлэн тэрхүү дуусгавар болголтын өдрөөр урьдчилан тодорхойлсон түвшнээс тухайн хувьцааны үнийн тусгайлан заасан индекс давж илүү гарах эсэхээс хамаарах эргэлтээс гаргалтын нэмэлт төлбөр төлөхийг шаарддаг. Хэрэв хувьцааны индекс нь уг урьдчилан тодорхойлсон дүнгээс давж илүү гарахгүй эсвэл түүнтэй тэнцүү бол эргэлтээс гаргалтын нэмэлт төлбөрийг төлөхгүй. Хэрэв хувьцааны индекс нь урьдчилан тодорхойлсон дүнгээс давж илүү гарвал эргэлтээс гаргалтын нэмэлт төлбөр нь дуусгавар болох үеийн хувьцааны индексийн түвшин ба өрийн бичгийг гаргах үеийн хувьцааны индексийн түвшин хоорондох ялгаарыг тэрхүү өрийн бичиг гаргалтын үеийн хувьцааны индексийн түвшинд хувааж, 1.5-аар үржүүлсэн дүнтэй тэнцүү байна. А байгууллага нь өрийн бичгийг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших эерэг санаа зорилготой ба чадвар, боломжтой байна. А байгууллага нь уг өрийн бичгийг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт гэж ангилж болох уу?**

Тийм. Өрийн бичиг нь 10ТН-ийн тогтмол төлбөртэй, дуусгавар болох тогтсон хугацаатай бөгөөд А байгууллага нь түүнийг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших эерэг санаа зорилготой ба чадвар, боломжтой тул уг өрийн бичгийг дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт гэж ангилж болно (УСНББОУС 29-ийн 10-р параграф). Гэвч өмчийн индексийн шинж нь уг өрийн үндсэн гэрээтэй нягт уялдаа холбоогүй дуудах опцион бөгөөд түүнийг УСНББОУС 29-ийн 12-р параграфын дагуу дагалдах үүсмэл хэрэглүүр гэж салгах тусгаарлах ёстой. 12ТН-ийн худалдан авалтын үнийг өрийн үндсэн хэрэглүүр ба дагалдах үүсмэл хэрэглүүрийн хооронд хуваарилна. Жишээлбэл; дагалдах опционы бодит үнэ цэнэ нь уг худалдан авалтын өдөр 4ТН байсан бол өрийн үндсэн хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрөх үед 8ТН-ээр хэмжинэ. Энэ тохиолдолд бондын үндсэн гэрээнд нуугдмал агуулагдаж буй 2ТН-ийн (10ТН-ийн үндсэн дүнгээс 8ТН-ийн анхны дансны үнийг хасах) хөнгөлөлтийг тэрхүү өрийн бичгийн дуусгавар болох өдөр хүртэлх хугацаанд үр ашигт хүүний арга ашиглан ашиг, алдагдалд тусгаж хорогдуулна.

Б.13 *Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгийн тодорхойлолт: Индекстэй уялдсан хүү*

**Хэрэв бондын хүүний төлбөр нь бараа бүтээгдэхүүний үнийн индекстэй уялдсан бөгөөд байгууллага нь уг бондыг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших эерэг санаа зорилготой ба чадвар, боломжтой бол дуусгавар болох үед тогтмол төлбөртэй, тогтсон дуусгавар хугацаатай бондыг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт гэж ангилж болох уу?**

Тийм. Гэвч бараа бүтээгдэхүүнтэй индекстэй уялдсан хүүний төлбөр нь дагалдах үүсмэл хэрэглүүрийг үүсгэх бөгөөд түүнийг тусдаа салгаж, бодит үнэ цэнээр нь үүсмэл хэрэглүүр гэж тайлагнана (УСНББОУС 29-ийн 12-р параграф). Өрийн үндсэн хэрэглүүрийг (дуусгавар болох үеийн тогтмол төлбөр) түүний дагалдах үүсмэл хэрэглүүрээс (индекстэй уялдсан хүүний төлбөрүүд) салган тусгаарлахад хялбар байхын тулд УСНББОУС 29-ийн 14-р параграфыг мөрдөхгүй.

Б.14 *Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгийн тодорхойлолт: Зэрэглэл буурсаны дараах борлуулалт*

**Зэрэглэл тогтоох агентлагаас тухайн гаргагчийн зээлийн зэрэглэлийг бууруулсаны дараа уг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтыг борлуулах нь уг байгууллага бусад хөрөнгө оруулалтыг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших санаа зорилгын талаар эргэлзээ төрүүлэх үү?**

Заавал тэгэх албагүй. Зэрэглэлийн бууралт нь тухайн гаргагчийн зээл төлөх чадвар буурсаныг илтгэх магадлалтай юм. Гаргагчийн зээл төлөх чадварын мэдэгдэхүйц доройтлын улмаас хийсэн борлуулалт нь УСНББОУС 29-д заасан нөхцлийг хангаж болох бөгөөд иймээс бусад хөрөнгө оруулалтыг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших уг байгууллагын санаа зорилгын талаар эргэлзээ үүсгэхгүй гэж УСНББОУС 29-д тусгайлан заасан байдаг. Гэвч анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн зээлийн зэрэглэлийг лавлагаа болгосноор тэрхүү зээл төлөх чадварын доройтлыг хянамгай шүүн тунгаах ёстой. Түүнчлэн, байгууллага нь УСНББОУС 29-д заасан нөхцлийг хангахын тулд хөрөнгө оруулалтыг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших гэж ангилах үед зэрэглэлийн бууралтыг ул үндэслэлтэйгээр урьдчилан таамаглах албагүй юм. Нэг ангийн доторх эсвэл зэрэглэлийн нэг ангиас түүний яг доод талын ангид шилжих зээлийн зэрэглэлийн багахан бууралтыг ихэвчлэн ул үндэслэлтэйгээр урьдчилан таамагласан гэж тооцдог. Хэрэв бусад мэдээллийн хамтаар зэрэглэлийн бууралт нь үнэ цэнийн бууралтын талаархи нотолгоогоор хангадаг бол зээл төлөх чадварын бууралтыг ихэвчлэн мэдэгдэхүйц гэж үзнэ.

Б.15 *Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгийн тодорхойлолт: Зөвшөөрөгдсөн борлуулалт*

**Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгийг тухайн байгууллагын удирдлага өөрчлөгдсөнөөр борлуулах нь бусад санхүүгийн хөрөнгийг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших гэсэн ангиллыг өөрчлөх үү?**

Тийм. Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгийн борлуулалт буюу шилжүүлэлт нь дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших гэсэн ангиллыг болиулж, өөрчилдөггүй байх үеийн жишээ болгож, удирдлагын өөрчлөлтийг УСНББОУС 29-ийн МЗУ35-р параграфт заагаагүй. Иймээс удирдлагын өөрчлөлтийн үр дүн болон хийгдэх борлуулалт нь хөрөнгө оруулалтыг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших уг байгууллагын санаа зорилгод эргэлзээ төрүүлнэ.

Үлгэрчлэн харуулвал: Х байгууллага нь дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших гэж ангилсан санхүүгийн хөрөнгийн багцтай. Удирдах зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу дээд удирдлагын багийг тухайн тайлант үед сольж өөрчилсөн. Шинэ удирдлага нь удирдах зөвлөлийн сонгож, баталсан өргөжүүлэх стратегийг хэрэгжүүлэхийн тулд уг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгийн зарим хэсгийг борлуулахыг хүссэн. Өмнөх удирдлагын баг нь тухайн байгууллагыг үүссэн цагаас хойш ажиллаж байсан бөгөөд Х байгууллага өмнө нь томоохон бүтцийн өөрчлөлт хийж байгаагүй боловч уг борлуулалт нь дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших бусад үлдсэн санхүүгийн хөрөнгийг тэрхүү дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших Х байгууллагын санаа зорилгод ямар нэг эргэлзээ төрүүлнэ.

*Б.16 Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгийн тодорхойлолт: Байгууллагын капиталын тусгай шаардлагуудын харуу болгон хийх борлуулалт*

**Зарим улс оронд банкны болон бусад салбарын зохицуулагчид нь тухайн байгууллагын эрсдлийн үнэлгээнд үндэслэн байгууллагын капиталын тусгай шаардлагуудыг тогтоож болох юм. Зохицуулагч нь салбарын капиталын шаардлагыг урьдчилан таамаглаагүй мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдүүлсэний улмаас өөрийн дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтаа борлуулдаг байгууллага нь бусад хөрөнгө оруулалтыг түүний дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших өөрийн санаа зорилгод заавал эргэлзээ төрүүлэхгүйгээр УСНББОУС 29-ийн дагуу ийм борлуулалтыг хийж болно гэдгийг УСНББОУС 29-ийн МЗУ35(д) параграфт заасан байдаг. Зохицуулагчдаас тогтоосон тухайн байгууллагын капиталын тусгай шаардлагуудын (өөрөөр хэлбэл, тухайн байгууллагад хамаарах боловч салбарт хамааралгүй капиталын шаардлагууд) мэдэгдэхүйц нэмэгдүүлэлтийн улмаас дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтыг борлуулах нь ийм эргэлзээ төрүүлэх үү?**

Тийм. Тухайн байгууллагын хяналтанд байдаггүй, дахин үл давтагдах ба уг байгууллага үл үндэслэлтэйгээр урьдчилан таамаглаж чадахгүй тусдаа үйл явдал болох капиталыг нэмэгдүүлэх шаардлагын үр дүнд хийгдсэн борлуулалт нь УСНББОУС 29-ийн 10-р параграфт заасан нөхцлийг хангана гэдгийг батлан харуулж чадахаас бусад тохиолдолд ийм борлуулалт нь бусад санхүүгийн хөрөнгийг түүний дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших тэрхүү байгууллагын санаа зорилгод “гажилт үүсгэнэ”.

Б.17 *Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгийн тодорхойлолт: Баталгаа болгосон барьцаа, Буцаан худалдан авах хэлцэл (репо), Үнэт цаас зээлдүүлэх хэлцэл*

**Хэрэв байгууллага нь санхүүгийн хөрөнгийг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших түүний санаа зорилгод саад учруулж болох хязгаарлалтанд захирагддаг бол тухайн байгууллага нь хөрөнгө оруулалтыг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмшинэ гэсэн батлан харуулсан чадвар боломжгүй байдаг. Баталгаа болгон барьцаалсан эсвэл репо болон үнэт цаас зээлдүүлэх ажил гүйлгээний дагуу нөгөө талд шилжүүлсэн ба хүлээн зөвшөөрсөн хэвээр байгаа өрийн хэрэглүүрийг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт гэж ангилж болохгүй гэсэн үг үү?**

Үгүй. Өрийн хэрэглүүрийг баталгаа болгон барьцаалсан эсвэл буцаан худалдан авах хэлцэл болон үнэт цаас зээлдүүлэх хэлцлийн зүйл байх нь тухайн өрийн хэрэглүүрийг түүний дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших уг байгууллагын санаа зорилго болон чадвар боломжинд заавал саад учруулахгүй. Гэвч байгууллага нь уг хэрэглүүрийг хэвээр хадгалах эсвэл түүний эрхийг буцаан авах боломжтой гэж хүлээхгүй байгаа бол тухайн байгууллага нь тэрхүү өрийн хэрэглүүрийг түүний дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших эерэг санаа зорилго болон чадвар боломжгүй гэж үзнэ.

Б.18 *Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгийн тодорхойлолт: “Гажилт”*

**Сайн дураар санал болгосон өрсөлдөөнт үнийн хариуд А байгууллага нь дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших гэж ангилсан өөрийн санхүүгийн хөрөнгийн мэдэгдэхүйц хэсгийг эдийн засгийн хувьд тааламжтай нөхцлөөр борлуулсан. А байгууллага нь уг борлуулалтын өдрөөс хойш олж эзэмшсэн аливаа санхүүгийн хөрөнгийг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших гэж ангилаагүй. Гэвч байгууллага нь дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших бусад үлдсэн хөрөнгө оруулалтыг ингэж дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших санаа зорилго хэвээр байгаа тул тэр хэвээр үлдээж, өөрчлөн дахин ангилаагүй. А байгууллага нь УСНББОУС 29-ийг даган мөрдсөн үү?**

Үгүй. Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших (ДБХХЭ) гэж ангилсан санхүүгийн хөрөнгийн мэдэгдэхүйц бус хэмжээнээс илүү дүн бүхий борлуулалт буюу шилжүүлэлт нь УСНББОУС 29-ийн 10-р параграф болон УСНББОУС 29-ийн МЗУ35-р параграфт заасан нөхцлүүд биелэгдэхгүй болоход хүргэх аливаа тохиолдолд хэрэглүүрийг уг ангилалд ангилах ёсгүй. Иймээс аливаа үлдсэн ДБХХЭ хөрөнгүүдийг борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө гэж дахин ангилна. Борлуулалт буюу шилжүүлэлт хийгдсэн тухайн тайлант үед дахин ангиллыг бүртгэх бөгөөд УСНББОУС 29-ийн 60-р параграфын дагуу ангиллын өөрчлөлт байдлаар тайлагнана. Байгууллага нь санхүүгийн хөрөнгийг ДБХХЭ гэж дахин ангилах боломжтой болохын тулд наад зах нь бүтэн хоёр санхүүгийн жил өнгөрсөн байх ёстой гэдгийг УСНББОУС 29-ийн 10-р параграфт тодорхой заасан байдаг.

Б.19 *Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгийн тодорхойлолт: “Гажилт” дүрмийг мөрдөхөд зориулсан дэд ангилал*

**Байгууллага нь УСНББОУС 29-ийн 10-р параграфт заасан, дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших ангиллын нөхцлүүдийг ам доллараар илэрхийлэгдсэн өрийн хэрэглүүр, еврогоор илэрхийлэгдсэн өрийн хэрэглүүр гэх мэт дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгийн янз бүрийн ангиудад тус тусад нь мөрдөж болох уу?**

Үгүй. УСНББОУС 29-ийн 10-р параграфт заасан “гажилтын дүрэм” нь ойлгомжтой тодорхой байдаг. Хэрэв байгууллага нь дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын мэдэгдэхүйц бус хэмжээнээс илүү дүн бүхий хэсгийг борлуулсан эсвэл дахин ангилсан бол тухайн байгууллага нь ийм аливаа санхүүгийн хөрөнгийг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө гэж ангилж болохгүй.

Б.20 *Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгийн тодорхойлолт: “Гажилт” дүрмийг нэгтгэлд мөрдөх*

**Эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээнд дэх өөр өөр байгууллагуудын, тухайлбал, хуулийн болон эдийн засгийн ялгаатай орчин бүхий янз бүрийн улс оронд байгаа тусдаа байгууллагуудын эзэмшиж буй дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгүүдэд тухайн байгууллага нь УСНББОУС 29-ийн 10-р параграфт заасан нөхцлүүдийг тус тусад нь мөрдөж болох уу?**

Үгүй. Хэрэв байгууллага нь нэгтгэсэн санхүүгийн тайландаа дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших гэж ангилсан хөрөнгө оруулалтын мэдэгдэхүйц бус хэмжээнээс илүү дүн бүхий хэсгийг борлуулсан эсвэл дахин ангилсан бол УСНББОУС 29-ийн 10-р параграфт заасан нөхцөл биелэгдэхээс бусад тохиолдолд тухайн байгууллага нь ийм аливаа санхүүгийн хөрөнгийг нэгтгэсэн санхүүгийн тайландаа дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө гэж ангилж болохгүй.

Б.21 *Зээл ба авлагын тодорхойлолт: Өмчийн хэрэглүүр*

**Эзэмшигч нь тогтмол буюу тодорхойлж болох төлбөр бүхий давуу эрхтэй хувьцаа гэх мэт өмчийн хэрэглүүрийг зээл ба авлагын бүрэлдэхүүнд оруулан ангилж болох уу?**

Тийм. Гаргагч нь үүсмэл бус өмчийн хэрэглүүрийг өр төлбөр гэж бүртгэдэг бөгөөд энэ нь тогтмол буюу тодорхойлж болох төлбөртэй ба идэвхитэй зах зээлд арилжигддаггүй бол хэрэглүүрийн эзэмшигч нь түүний тодорхойлолтын бусад нөхцөл хангагдах тохиолдолд ийм өмчийн хэрэглүүрийг зээл ба авлагын бүрэлдэхүүнд оруулан ангилж болно. Санхүүгийн хэрэглүүрийн гаргагчийн зүгээс тухайн санхүүгийн хэрэглүүрийг өр төлбөр эсвэл өмчийн хэрэглүүр гэж ангилах талаархи заавар удирдамжийг УСНББОУС 27-гийн 13-27-р параграфт тусгасан. Хэрэв хэрэглүүр нь УСНББОУС 28-д заасан өмчийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангаж байвал эзэмшигч нь тухайн хэрэглүүрийг зээл ба авлагын бүрэлдэхүүнд оруулан ангилж болохгүй.

Б.22 *Зээл ба авлагын тодорхойлолт: Бусад банкууд дахь банкны хадгаламж*

**Банк нь төв банк болон бусад банкуудад хугацаатай хадгаламж байршуулдаг. Хадгаламжийн гэрчилгээг зарим үед арилжих боломжтой, зарим үед ийм боломжгүй байдаг. Хэдийгээр арилжих боломжтой ч гэсэн хадгаламж эзэмшигч банк нь үүнийг худалдан борлуулах санаа зорилготой эсвэл ийм зорилгогүй байж болох юм. Ийм хадгаламж нь УСНББОУС 29-ийн 10-р параграфын дагуу зээл ба авлагын ангилалд хамаарах уу?**

Хадгаламж эзэмшигч банк нь уг хэрэглүүрийг нэн даруй эсвэл ойрын хугацаанд борлуулах санаа зорилготой, энэ тохиолдолд уг хадгаламжийг худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө гэж ангилахаас бусад тохиолдолд тэрхүү хадгаламжийн гэрчилгээг арилжиж болох эсэхээс үл хамааран ийм хадгаламж нь зээл ба авлагын тодорхойлолтыг хангана.

Б.23 *Хорогдуулсан өртгийн тодорхойлолт: Тогтмол эсвэл зах зээлд суурилсан хувьсах хүүтэй, хугацаагүй өрийн хэрэглүүр*

**Гаргагч нь үндсэн дүнг буцаан төлөх үүрэг хүлээдэггүй бөгөөд хорогдуулсан өртгөөр хэмжих шаардлагатай өрийн хэрэглүүрийг зарим үед байгууллагууд нь худалдан авах буюу гаргадаг. Хүүг тогтмол түвшнээр эсвэл хувьсах түвшнээр төлж болно. Хүүний түвшин нь тогтмол эсвэл зах зээлд суурилсан хувьсах түвшин гэж тусгайлан заасан бол хорогдуулсан өртгийг тодорхойлох зорилгын хувьд тухайн анх төлсөн буюу хүлээн авсан дүн ба тэг дүнгийн (“дуусгавар болгох дүн”) хоорондох зөрүүг анхны хүлээн зөвшөөрөлтийн үед шууд хорогдуулах уу?**

Үгүй. Хүүний түвшин нь тогтмол эсвэл зах зээлд суурилсан хувьсах түвшин гэж тусгайлан заасан бол үндсэн дүнг буцаан төлөхгүй учраас уг анхны дүн ба дуусгавар болгох дүнгийн хоорондох зөрүүг хорогдуулахгүй. Хүүний төлбөр нь тогтмол эсвэл зах зээлд суурилсан хувьсах бөгөөд хязгааргүй хугацаанд төлөгдөх учраас уг хорогдуулсан өртөг (үр ашигт хүүний түвшнээр дискаунтчилсан ирээдүйн мөнгөн зарлагын гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ) нь тайлант үе бүрийн үндсэн дүнтэй тэнцүү байна (УСНББОУС 29-ийн 10-р параграф).

Б.24 *Хорогдуулсан өртгийн тодорхойлолт: Буурах хүүний түвшин бүхий хугацаагүй өрийн хэрэглүүр*

**Хэрэв хугацаагүй өрийн хэрэглүүрийн тогтоосон хүүний түвшин нь цаг хугацааны явцад буурдаг бол хорогдуулсан өртөг нь тайлант үе бүрийн үндсэн дүнтэй тэнцүү байх уу?**

Үгүй. Эдийн засгийн талаас авч үзвэл, хүүний бүх эсвэл зарим төлбөр нь үндсэн дүнгийн буцаан төлөлт байдаг. Жишээлбэл; хүүний түвшинг эхний арван жилийн хугацаанд 16 хувиар, үүнээс хойшхи тайлант үеүдэд тэг хувиар тогтоож болох юм. Хүүний төлбөрийн зарим хэсэг нь үндсэн дүнгийн буцаан төлөлтийг илэрхийлдэг учраас энэ тохиолдолд анхны дүнг үр ашигт хүүний аргыг ашиглан эхний арван жилийн хугацаанд тэг хүртэл хорогдуулна. Үүнээс хойшхи тайлант үеүдийн ирээдүйн мөнгөн зарлагын гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ нь тэг (дараагийн тайлант



үеүдэд үндсэн дүн эсвэл хүүний ирээдүйн мөнгөн төлбөр байхгүй) учраас хорогдуулсан өртөг нь 10 жилийн дараа тэг байна.

**Б.25 Хорогдуулсан өртгийг тооцоолох жишээ: Санхүүгийн хөрөнгө**

**Бодит үнэ цэнийн үнэлгээнд оруулаагүй бөгөөд тогтоосон дуусгавар болох хугацаа бүхий санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Хорогдуулсан өртгийг хэрхэн тооцоолох вэ?**

Хорогдуулсан өртгийг УСНББОУС 29-д заасны дагуу үр ашигт хүүний аргыг ашиглан тооцоолдог. Угаасаа санхүүгийн хэрэглүүрийн хувьд үр ашигт хүүний түвшин нь тухайн санхүүгийн хэрэглүүртэй холбоотойгоор тооцоолсон мөнгөн гүйлгээг тэрхүү хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацаанд эсвэл хэрэв тохиромжтой бол үүнээс арай богино хугацаанд дискаунтчилж, анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн дансны цэвэр үнэтэй яг тэнцүү болгох тийм хувь хэмжээ байдаг. Үр ашигт хүүний түвшний салшгүй нэг хэсэг байдлаар төлсөн буюу хүлээн авсан бөгөөд тухайн ажил гүйлгээний зардалд шууд хамааруулж болох бүх хураамж, оноо болон бусад бүх хөнгөлөлт, урамшууллыг уг тооцоололд хамааруулна.

Үр ашигт хүүний аргыг ашиглан хорогдуулсан өртгийг хэрхэн тооцоолохыг дараах жишээнд үлгэрчлэн харуулав. А байгууллага нь дуусгавар болох хүртэл таван жилийн үлдсэн хугацаатай өрийн хэрэглүүрийг түүний 1,000ТН-ийн бодит үнэ цэнээр (үүнд ажил гүйлгээний зардал багтсан) худалдан авсан. Уг хэрэглүүр нь 1,250ТН-ийн үндсэн дүнтэй ба жил бүр төлөгдөх 4.7 хувийн тогтмол хүүтэй (1,250ТН x 4.7 хувь = жилд 59ТН) юм. Зээлдэгч нь уг өрийн хэрэглүүрийг урьдчилж төлөх сонголттой бөгөөд ингэж урьдчилж төлснөөр ямар нэг торгууль төлөхгүй гэж гэрээнд тусгайлан заасан. Анх үүсэх үед тухайн байгууллага нь уг зээлдэгч урьдчилж төлөхгүй гэж бодож байна.

Хүүний орлого ба анхны хөнгөлөлтийг уг өрийн хэрэглүүрийн хугацаанд түүний дансны үнээс тогтмол хувь хэмжээгээр хуваарилахын тулд хүүг жил бүр 10 хувиар хуримтлуулах ёстой гэдгийг харуулж болох юм. Өрийн хэрэглүүрийн хорогдуулсан өртөг, хүүний орлого, мөнгөн гүйлгээний талаархи тайлант үе тус бүрийн мэдээллийг доорх хүснэгтэнд харуулав.

Жил	(а) Тухайн жилийн эхэн дэх хорогдуулсан өртөг	(б=а x 10%) Хүүний орлого	(в) Мөнгөн гүйлгээ	(г = а+б-в) Тухайн жилийн эцэс дэх хорогдуулсан өртөг
20X0	1,000	100	59	1,041
20X1	1,041	104	59	1,086
20X2	1,086	109	59	1,136
20X3	1,136	113	59	1,190
20X4	1,190	119	1,250+59	-

20X2 оны эхний өдөр байгууллага нь өөрийн мөнгөн гүйлгээний тооцооллыг хянан засварласан. Байгууллага нь үндсэн дүнгийн 50 хувийг 20X2 оны эцэст урьдчилж төлөх ба үлдсэн 50 хувийг 20X4 оны эцэст төлнө гэж хүлээж байна. Өрийн хэрэглүүрийн 20X2 оны эхний үлдэгдлийг УСНББОУС 29-ийн МЗУ20-р параграфын

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

дагуу тохируулна. Байгууллага нь 20X2 онд болон дараагийн жилүүдэд авахаар хүлээж буй дүнг анхны үр ашигт хүүний түвшинг (10 хувь) ашиглан дискаунтчилсанаар уг тохируулсан дүнг тооцоолно. Ингэснээр 20X2 оны шинэ эхний үлдэгдэл нь 1,138ТН болно. 52ТН-ийн (1,138ТН-1,086ТН) тохируулгыг 20X2 онд ашиг, алдагдалд бүртгэнэ. Тооцооллын өөрчлөлтийг харгалзсанаар тохируулсан уг хорогдуулсан өртөг, хүүний орлого, мөнгөн гүйлгээний талаархи мэдээллийг доорх хүснэгтэнд харуулав.

Жил	(а) Тухайн жилийн эхэн дэх хорогдуулсан өртөг	(б=а x 10%) Хүүний орлого	(в) Мөнгөн гүйлгээ	(г = а+б-в) Тухайн жилийн эцэс дэх хорогдуулсан өртөг
20X0	1,000	100	59	1,041
20X1	1,041	104	59	1,086
20X2	1,086+52	114	625+59	568
20X3	568	57	30	595
20X4	595	60	625+30	-

Хэрэв өрийн хэрэглүүрийн үнэ цэнэ нь тухайлбал, 20X3 оны эцэст буурсан бол анхны үр ашигт хүүний түвшингээр (10%) дискаунтчилсан ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ ба дансны үнийн (595ТН) хоорондох зөрүү байдлаар үнэ цэнийн бууралтын гарзыг тооцоолно.

**Б.26** *Хорогдуулсан өртгийг тооцоолох жишээ: Шаталсан хүүний төлбөр бүхий өрийн хэрэглүүр*

**Зарим үед байгууллага нь тухайн өрийн хэрэглүүрийн хугацаанд аажим нэмэгдэх эсвэл буурах урьдчилж тодорхойлсон хүүний түвшин (“шаталсан хүү”) бүхий өрийн хэрэглүүрийг худалдан авах буюу гаргадаг. Шаталсан хүүтэй бөгөөд дагалдах үүсмэл хэрэглүүргүй өрийн хэрэглүүрийг 1,250ТН-ээр гаргасан бөгөөд дуусгавар болгох дүн нь 1,250ТН бол түүний хорогдуулсан өртөг нь уг өрийн хэрэглүүрийн хугацааны туршид тайлант үе бүрд 1,250ТН-тэй тэнцүү байх уу?**

Үгүй. Хэдийгээр анхны дүн ба дуусгавар болгох дүн хоорондоо зөрүүгүй боловч байгууллага нь дансны үнээс тогтмол хувь хэмжээгээр тооцохын тулд уг өрийн хэрэглүүрийн хугацааны туршид хүүний төлбөрийг хуваарилахдаа үр ашигт хүүний аргыг ашиглана (УСНББОУС 29-ийн 10-р параграф).

Тухайн өрийн хэрэглүүрийн хугацаанд аажим нэмэгдэх эсвэл буурах урьдчилж тодорхойлсон хүүний түвшин (“шаталсан хүү”) бүхий өрийн хэрэглүүрийн хувьд үр ашигт хүүний аргыг ашигласнаар хорогдуулсан өртгийг хэрхэн тооцоолохыг дараах жишээнд үлгэрчлэн харуулав.

2000 оны 01 дүгээр сарын 01-нд А байгууллага нь өрийн хэрэглүүрийг 1,250ТН-ээр гаргасан. Үндсэн дүн нь 1,250ТН бөгөөд уг өрийн хэрэглүүрийг 2004 оны 12 дугаар сарын 31-нд буцаан төлнө. Хүүний түвшинг үндсэн дүнгийн хувийн жингээр дараах байдлаар уг өрийн хэрэглүүрийн гэрээнд тусгайлан заасан. Үүнд: 2000 онд 6.0 хувь (75ТН), 2001 онд 8.0 хувь (100ТН), 2002 онд 10.0 хувь (125ТН), 2003 онд 12.0 хувь

(150ТН), 2004 онд 16.4 хувь (205ТН). Энэ тохиолдолд ирээдүйн мөнгөн зарлагын гүйлгээг түүний дуусгавар болох хугацаа хүртэл яг тэнцүү хувь хэмжээгээр дискаунтчлах хүүний түвшин нь 10 хувь байна. Иймээс тайлант үе тус бүрийн хорогдуулсан өртгийг тодорхойлох зорилгоор хүүний мөнгөн төлбөрүүдийг уг өрийн хэрэглүүрийн хугацааны туршид дахин хуваарилна. Тайлант үе тус бүрийн хувьд тухайн тайлант үеийн эхэн дэх хорогдуулсан өртгийг 10 хувийн үр ашигт хүүний түвшнээр үржүүлж, тэрхүү хорогдуулсан өртөг дээр нэмнэ. Уг тайлант үеийн аливаа мөнгөн төлбөрийг тэрхүү гарсан дүнгээс хасна. Үүний үр дүнд тайлант үе бүрийн хорогдуулсан өртөг нь дараах байдалтай байна:

Жил	(а) Тухайн жилийн эхэн дэх хорогдуулсан өртөг	(б=а x 10%) Хүүний орлого	(в) Мөнгөн гүйлгээ	(г = а+б-в) Тухайн жилийн эцэс дэх хорогдуулсан өртөг
20X0	1,250	125	75	1,300
20X1	1,300	130	100	1,330
20X2	1,330	133	125	1,338
20X3	1,338	134	150	1,322
20X4	1,322	133	1,250+205	-

Б.27 *Ердийн нөхцөл бүхий гэрээ: Тогтсон зах зээлгүй*

**Санхүүгийн хөрөнгийг худалдан авах гэрээний хувьд түүнийг арилжих тогтсон зах зээл байхгүй бол ийм гэрээ нь ердийн нөхцөл бүхий гэрээ мөн үү?**

Тийм. Тухайн хамаарах зах зээл дэх зохицуулалт буюу тогтсон журмаар ерөнхийдөө тогтоодог цаг хугацааны дотор уг хөрөнгийг нийлүүлэхийг шаарддаг нөхцлийг УСНББОУС 29-ийн 10-р параграфт заасан байдаг. УСНББОУС 29-ийн 10-р параграфт хэрэглэсэн уг зах зээл гэсэн нэр томъёо нь албан ёсны хөрөнгийн бирж эсвэл зохион байгуулалттай биржийн бус зах зээлээр хязгаарлагдахгүй юм. Харин энэ нь санхүүгийн хөрөнгийг хэвийн байдлаар арилжаалдаг орчин гэсэн утгатай юм. Хүлээн зөвшөөрөгдөх цаг хугацаа гэдэг нь ажил гүйлгээг хийх ба хаалтын бичиг баримтыг бэлтгэх, эцэслэн дуусгахад талуудад шаардлагатай ул үндэслэлтэй, хэвийн тогтсон хугацаа юм.

Жишээлбэл; хаалттай захиалгаар гаргах санхүүгийн хэрэглүүрийн зах зээл нь мөн хамаарах зах зээл болно.

Б.28 *Ердийн нөхцөл бүхий гэрээ: Форвард гэрээ*

**ABC байгууллага нь M байгууллагын нэг сая ширхэг энгийн хувьцааг хоёр сарын дараа нэгжийг нь 10ТН-ээр худалдах авахын тулд форвард гэрээ байгуулсан. Уг гэрээ нь биржид арилждаг гэрээ биш юм. Энэ гэрээний дагуу ABC байгууллага нь хувьцааг биетээр хүлээн авах ба нөгөө талдаа 10 сая ТН-ийг мөнгөөр төлөх шаардлагатай. M байгууллагын хувьцааг нийтийн идэвхитэй зах зээлд өдөрт дундажаар 100,000 ширхэгийг арилжаалдаг.**

**Ердийн нөхцлөөр нийлүүлэлт нь 3 өдрийн дотор хийгддэг. Энэхүү форвард гэрээг ердийн нөхцөл бүхий гэрээ гэж үзэх үү?**

Үгүй. Тухайн хамаарах зах зээл дэх зохицуулалт буюу журмаар тогтоосны дагуу уг гэрээг барагдуулдаггүй учраас үүнийг үүсмэл хэрэглүүр гэж тайлагнах ёстой.

**Б.29** *Ердийн нөхцөл бүхий гэрээ: Хэвийн барагдуулалтын аль нөхцлийг мөрдөх вэ?*

**Хэрэв байгууллагын санхүүгийн хэрэглүүрийг нэгээс олон идэвхитэй зах зээлд арилждаг бөгөөд төлбөр барагдуулалтын нөхцөл нь идэвхитэй зах зээл бүрд өөр бол тэдгээр санхүүгийн хөрөнгийг худалдан авах гэрээ нь ердийн нөхцөл бүхий гэрээ эсэхийг үнэлэхдээ аль нөхцлийг мөрдөх вэ?**

Мөрдөх нөхцөл нь худалдан авалт бодитойгоор хийгдсэн зах зээлд хамаарах нөхцөл байна.

Үлгэрчлэн харуулвал: XYZ байгууллага нь ABC байгууллагын нэг сая ширхэг хувьцааг АНУ-ын хөрөнгийн бирж дээрээс, тухайлбал брокероор дамжуулан худалдан авсан. Уг гэрээний барагдуулалтын өдөр нь ажлын зургаан өдрийн дараа болно. АНУ-ын хөрөнгийн бирж дээр өмчийн хувьцааны арилжааг хэвийн нөхцлөөр ажлын гурван өдрийн дотор барагдуулдаг. Арилжааг ажлын зургаан өдрийн дараа барагдуулах учраас энэ нь ердийн нөхцөл бүхий арилжааны чөлөөлөх нөхцлийг хангахгүй.

Гэвч XYZ байгууллага нь ажлын зургаан өдөр бүхий хэвийн барагдуулалтын хугацаатай гадаадын хөрөнгийн бирж дээр уг ажил гүйлгээг хийсэн бол энэхүү гэрээ нь ердийн нөхцөл бүхий арилжааны чөлөөлөх нөхцлийг хангана.

**Б.30** *Ердийн нөхцөл бүхий гэрээ: Дуудах опционоор хийгдэх хувьцааны худалдан авалт*

**А байгууллага нь XYZ байгууллагын 100 ширхэг хувьцааг дараагийн гурван сар доторх дурын хугацаанд нэгжийг 100ТН-ээр худалдан авах боломжийг түүнд олгох дуудах опционыг олон нийтийн зах зээлээс худалдан авсан. Хэрэв А байгууллага нь опционоо хэрэгжүүлвэл уг опционы зах зээлийн зохицуулалт буюу тогтсон журмын дагуу тухайн ажил гүйлгээг 14 хоногийн дотор барагдуулна. XYZ байгууллагын хувьцаа нь 3 хоногийн дотор барагдуулахыг шаарддаг олон нийтийн идэвхитэй зах зээлд арилжаалагддаг. Опционы хэрэгжүүлэлтээр хийгдэх хувьцааны худалдан авалт нь хувьцааны ердийн нөхцлөөр худалдан авалт мөн үү?**

Тийм. Опционы барагдуулалтыг тухайн опционы зах зээл дэх зохицуулалт буюу журмаар удирдан зохицуулдаг бөгөөд 14 хоногийн дотор хувьцааг олгосноор хийгдэх барагдуулалт нь ердийн нөхцөл бүхий ажил гүйлгээ болох тул уг опционыг хэрэгжүүлснээр түүнийг цаашид үүсмэл хэрэглүүр гэж тайлагнахгүй.

Б.31 *Арилжааны өдрийн эсвэл барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийг ашигласнаар санхүүгийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх ба үл хүлээн зөвшөөрөх*

**УСНББОУС 29 нь арилжааны өдрийн эсвэл барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийг ашигласнаар санхүүгийн санхүүгийн хөрөнгийг хүлээн зөвшөөрөх ба үл хүлээн зөвшөөрөх талаархи тусгай дүрэмтэй байдаг. Хадгаламжийн өглөг, худалдааны өглөгийн ажил гүйлгээ гэх мэт санхүүгийн өр төлбөр гэж ангилсан санхүүгийн хэрэглүүрүүдийн ажил гүйлгээнд энэхүү дүрмийг мөрдөх үү?**

Үгүй. Санхүүгийн өр төлбөр гэж ангилсан санхүүгийн хэрэглүүрийн ажил гүйлгээний хувьд УСНББОУС 29 нь арилжааны өдрийн нягтлан бодох бүртгэл ба барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийн талаархи аливаа тусгай шаардлагуудыг тусгаагүй байдаг. Иймээс УСНББОУС 29-ийн 18-р параграф ба УСНББОУС 29-ийн 41-р параграфт заасан хүлээн зөвшөөрөлтийн болон үл хүлээн зөвшөөрөлтийн ерөнхий шаардлагуудыг мөрдөнө. Байгууллага нь “тухайн хэрэглүүрийн гэрээний нэг тал болсон” өдөр санхүүгийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө гэж УСНББОУС 29-ийн 16-р параграфт заасан. Талуудын аль нэг нь үүргээ гүйцэтгэсэн эсвэл тухайн гэрээ нь УСНББОУС 29-ийн цар хүрээнээс чөлөөлөгдөхгүй үүсмэл гэрээ байхаас бусад тохиолдолд ийм гэрээг ерөнхийдөө хүлээн зөвшөөрдөггүй. Санхүүгийн өр төлбөрийг зөвхөн дуусгавар болгосон үед, өөрөөр хэлбэл гэрээнд тусгайлан заасан үүргийг биелүүлсэн эсвэл чөлөөлсөн, цуцалсан, хугацаа дууссан үед үл хүлээн зөвшөөрнө гэж УСНББОУС 29-ийн 41-р параграфт заасан байдаг.

### **Хэсэг В: Дагалдах үүсмэл хэрэглүүр**

В.1 *Дагалдах үүсмэл хэрэглүүр: Өрийн үндсэн хэрэглүүрээс салган тусгаарлалт*

**Опцион бус дагалдах үүсмэл хэрэглүүрийг тухайн өрийн үндсэн хэрэглүүрээс салган тугаарлах шаардлагатай бол уг өрийн үндсэн хэрэглүүрийн болон дагалдах үүсмэл хэрэглүүрийн нөхцлүүдийг хэрхэн тодорхойлох вэ? Жишээлбэл; өрийн үндсэн хэрэглүүр нь тогтмол хүүтэй хэрэглүүр, хувьсах хүүтэй хэрэглүүр эсвэл тэг купонтой хэрэглүүр байх уу?**

Өрийн үндсэн хэрэглүүрийн нөхцөл нь уг холимог (нэгдсэн) хэрэглүүрийн тогтоосон буюу дам илэрхийлсэн гол нөхцлүүдийг тусгадаг. Дам илэрхийлсэн эсвэл тогтоосон нөхцлүүд байхгүй бол байгууллага нь тухайн нөхцлийн талаар өөрийн шүүн тунгаалтыг хийнэ. Гэвч байгууллага нь тусгайлан заагаагүй бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлж болохгүй эсвэл уг холимог хэрэглүүрт нэгэнт тодорхой тусгагдаагүй, өөрөөр хэлбэл одоо байхгүй мөнгөн гүйлгээг бий болгож чадахгүй тийм дагалдах үүсмэл хэрэглүүрийг салган тусгаарлахад хүргэх байдлаар тухайн өрийн үндсэн хэрэглүүрийн нөхцлүүдийг тогтоож болохгүй юм. Жишээлбэл; таван жилийн хугацаатай өрийн хэрэглүүр нь жил бүрийн 40,000ТН-ийн тогтмол хүүний төлбөрүүдтэй бөгөөд түүний дуусгавар болгох 1,000,000ТН-ийн үндсэн дүнг өмчийн үнийн индексээр үржүүлэн тогтоодог бол уг хэрэглүүрийг тогтмол хүүтэй үндсэн гэрээ гэж тодорхойлохын оронд, хөвөх хүүтэй үндсэн гэрээ ба цэвэр дүнгээр

тооцогдох хөвөх хүүтэй хэсэг бүхий өмчийн дагалдах своп гэж тодорхойлох нь тохиромжгүй юм. Энэ жишээний хувьд, тухайн холимог хэрэглүүрт хөвөх хүүний түвшин бүхий мөнгөн гүйлгээ байхгүй учраас үндсэн гэрээ нь жил бүр 40,000ТН төлөх тогтмол хүүтэй өрийн хэрэглүүр болно.

Түүнчлэн, уг холимог хэрэглүүр үүссэн үед тухайн дагалдах үүсмэл хэрэглүүрийг тэг (0) бодит үнэ цэнэтэй байлгах тийм байдлаар форвард, своп гэх мэт опцион бус дагалдах үүсмэл хэрэглүүрийн нөхцлүүдийг тодорхойлох ёстой. Опцион бус дагалдах үүсмэл хэрэглүүрүүдийг өөр бусад нөхцлөөр салган тусгаарлахыг зөвшөөрдөг бол нэг холимог хэрэглүүрийг өрийн үндсэн хэрэглүүр ба дагалдах үүсмэл хэрэглүүрийн янз бүрийн олон хослолуудаар задалж болох юм. Жишээлбэл; дагалдах үүсмэл хэрэглүүрийг хөшүүрэг үүсгэх нөхцлөөр, тухайн холимог хэрэглүүрт хараахан тусгагдаагүй жигд бус буюу бусад зарим эрсдлээр салган тусгаарлах. Иймээс тухайн холимог хэрэглүүрийг үүсэх үед тэг (0)-ээс өөр бодит үнэ цэнэ бий болгох үр дүн бүхий нөхцлүүдээр уг опцион бус дагалдах үүсмэл хэрэглүүрийг салган тусгаарлах нь тохиромжгүй юм. Дагалдах үүсмэл хэрэглүүрийн нөхцлийн тодорхойлолт нь уг санхүүгийн хэрэглүүрийг гаргах үед оршин байсан нөхцлүүдэд үндэслэдэг.

## *В.2 Дагалдах үүсмэл хэрэглүүр: Дагалдах опционыг салган тусгаарлалт*

**Асуулт В.1-ийн хариулт нь тухайн холимог хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрөх үед дагалдах үүсмэл хэрэглүүр тэг (0) бодит үнэ цэнэтэй байх тийм үр дүнтэйгээр уг опцион бус дагалдах үүсмэл хэрэглүүрийн нөхцлийг тодорхойлох хэрэгтэй гэдгийг илэрхийлсэн. Опционд суурилсан дагалдах үүсмэл хэрэглүүрийг салган тусгаарлах тохиолдолд уг холимог хэрэглүүр үүссэн өдрөөрх тухайн дагалдах үүсмэл хэрэглүүр нь тэг (0) бодит үнэ цэнэтэй эсвэл тэг (0) дотоод үнэ цэнэтэй (өөрөөр хэлбэл, мөнгөн ашиггүй) байхуйцаар тэрхүү дагалдах опционы нөхцлийг тодорхойлох ёстой юу?**

Үгүй. Доор авч хэлэлцсэнчлэн, опционд суурилсан дагалдах үүсмэл хэрэглүүр бүхий холимог хэрэглүүрийн эдийн засгийн төлөв байдал нь тэрхүү холимог хэрэглүүр дэх опционы шинжийн хувьд тусгайлан заасан хэрэгжүүлэх үнээс (буюу хэрэгжүүлэх түвшнээс) үндсэндээ хамаардаг. Иймээс опционд суурилсан дагалдах хэрэглүүрийн (үүн дотроо, аливаа дагалдах буцаах эрх, дуудах эрх, хүүний түвшний дээд хэмжээ, хүүний түвшний доод хэмжээ, холимог хэрэглүүр дэх хүүний түвшний дээд, доод хэмжээний болон свопын шинж) салган тусгаарлалт нь уг холимог хэрэглүүрт баримтжуулсан опционы шинжийн тогтоосон нөхцлүүдэд үндэслэвэл зохино. Иймээс уг дагалдах үүсмэл хэрэглүүр нь тухайн холимог хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрөх үед заавал тэг (0)-тэй тэнцүү бодит үнэ цэнэ буюу дотоод үнэ цэнэтэй байх албагүй юм.

Хэрэв байгууллага нь опционд суурилсан дагалдах үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тэг (0) байхуйцаар тухайн дагалдах үүсмэл хэрэглүүрийн нөхцлийг тодорхойлох шаардлагатай бол тэрхүү опционыг тодорхой бус мөнгөн алдагдалтай болгох тийм үр дүнтэйгээр уг хэрэгжүүлэх үнийг (эсвэл хэрэгжүүлэх түвшинг) ерөнхийдөө тодорхойлох шаардлагатай байдаг. Энэ нь опционы шинжийг хэрэгжүүлэх тэг (0) магадлалтай гэсэн утгыг илэрхийлнэ. Гэвч холимог хэрэглүүр дэх опционы шинжийг хэрэгжүүлэх магадлал нь ерөнхийдөө тэг (0) байдаггүй

учраас энэ нь анхны бодит үнэ цэнэ тэг (0) гэж үзэх тухайн холимог хэрэглүүрийн эдийн засгийн магадлалт шинж чанартай нийцэхгүй юм. Үүнтэй адилаар, хэрэв байгууллага нь опционд суурилсан дагалдах үүсмэл хэрэглүүрийн дотоод үнэ цэнийг тэг (0) байхуйцаар тухайн дагалдах үүсмэл хэрэглүүрийн нөхцлийг тодорхойлох шаардлагатай бол хэрэгжүүлэх үнэ (эсвэл хэрэгжүүлэх түвшин) нь тухайн холимог хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрөх өдрөөрх уг суурь хувьсагчийн үнэ (буюу түвшин)-тэй тэнцүү байна гэж төсөөлөх ёстой. Энэ тохиолдолд опционы бодит үнэ цэнэ нь зөвхөн цаг хугацааны үнэ цэнээс бүрдэнэ. Гэвч тохиролцсон хэрэгжүүлэх үнэ нь тухайн холимог хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрөх өдрөөрх уг суурь хувьсагчийн үнэ (буюу түвшин)-тэй үнэхээр тэнцүү байхаас бусад тохиолдолд ийм төсөөлөл нь тухайн холимог хэрэглүүрийн эдийн засгийн магадлалт шинж чанартай, үүн дотроо опционы шинжийг хэрэгжүүлэх магадлалтай нийцэхгүй юм.

Опционы нөхцлөөр бол суурь зүйлийн үнэ ба уг опционы хэрэгжүүлэх үнийн хоорондох зөрүүд үндэслэсэн төлбөр нь тэрхүү тохиролцсон хэрэгжүүлэх үнэ болон ирээдүйн тусгайлан заасан өдөр буюу өдрүүд дэх тухайн суурь зүйлийн үнэ хоорондох харилцан холбооноос хамааран хийгдэж эсвэл хийгдэхгүй байж болно гэж үздэг, харин форвардын нөхцлөөр бол суурь зүйлийн үнэ ба форвард үнийн хоорондох зөрүүд үндэслэсэн төлбөр нь уг тогтоосон өдрөөр хийгддэг тул опционд суурилсан, дагалдах үүсмэл хэрэглүүрийн эдийн засгийн шинж чанар нь форвардад суурилсан дагалдах үүсмэл хэрэглүүрээс (үүн дотроо, форвард ба своп) үндсэндээ өөр байдаг. Иймээс опционд суурилсан дагалдах үүсмэл хэрэглүүрийн хэрэгжүүлэх үнийг тохируулах нь уг холимог хэрэглүүрийн шинж чанарыг өөрчилдөг. Нөгөө талаас, өрийн үндсэн хэрэглүүр дэх опцион бус дагалдах үүсмэл хэрэглүүрийн нөхцлийг тухайн холимог хэрэглүүр үүссэн өдрөөр тэг (0)-ээс өөр ямар нэг дүн бүхий бодит үнэ цэнэтэй байхаар тодорхойлсон бол тэрхүү дүн нь авсан эсвэл өгсөн зээлийг үндсэндээ илэрхийлнэ. Иймээс Асуулт В.1-ийн хариултанд авч хэлэлцсэнчлэн, тухайн холимог хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрөх үед тэг (0)-ээс өөр бодит үнэ цэнэ бий болгох үр дүн бүхий нөхцлүүдээр уг өрийн үндсэн хэрэглүүр дэх опцион бус дагалдах үүсмэл хэрэглүүрийг салган тусгаарлах нь тохиромжгүй юм.

### В.3 *Дагалдах үүсмэл хэрэглүүр: Хөрвөх бондын тайлагнал*

**Дуусгавар болох хугацаанаас өмнө тухайн гаргагч байгууллагын эсвэл өөр байгууллагын өмчийн хэрэглүүрт хөрвөх бондын хөрөнгө оруулалтын (санхүүгийн хөрөнгийн) нягтлан бодох бүртгэлийн арга хандлага нь ямар байх вэ?**

Дуусгавар болох хугацаанаас өмнө хөрвөдөг тийм хөрвөх бондод оруулсан хөрөнгө оруулалтыг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт гэж ангилал нь уг хөрвөх шинж, өөрөөр хэлбэл дуусгавар болох хугацаанаас өмнө өмчийн хэрэглүүрт хөрвүүлэх эрхийн төлөө төлсөн зорилготой нийцэхгүй учраас ийм бондыг ерөнхийдөө дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших гэж ангилдаггүй.

Хөрвөх бондод оруулсан хөрөнгө оруулалтыг худалдаа арилжааны зорилгоор худалдан аваагүй бол түүнийг борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө гэж ангилж болно. Өмчид хөрвөх опцион нь дагалдах үүсмэл хэрэглүүр юм.

Хэрэв бондыг борлуулах боломжтой гэж ангилсан бол (өөрөөр хэлбэл, бондыг борлуулах хүртэл түүний бодит үнэ цэнийн өөрчлөлтийг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө) уг өмчид хөрвөх опционыг (дагалдах үүсмэл хэрэглүүрийг) салган тусгаарлана. Тухайн бондын хувьд төлсөн дүнг хөрвөх опционгүй өрийн хэрэглүүр ба өмчид хөрвөх опционы хооронд салгаж хуваана. Опцион нь мөнгөн гүйлгээний хейжийн харилцааны нэг хэсэг байхаас бусад тохиолдолд уг өмчид хөрвөх опционы бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Хэрэв бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрснөөр тухайн хөрвөх бондыг бодит үнэ цэнээр хэмждэг бол дагалдах үүсмэл хэрэглүүрийг түүний бондын үндсэн хэрэглүүрээс салган тусгаарлахыг зөвшөөрөхгүй.

#### ***V.4 Дагалдах үүсмэл хэрэглүүр: Өмчийн урамшуулал***

**Тэргүүн бус ээлжийн эрхтэй зээл олгож буй хамтарсан өмчит байгууллагууд нь хүү ба үндсэн зээлийг буцаан төлүүлэхээс гадна хэрэв тухайн зээлдэгч өөрийн хувьцааг хөрөнгийн биржид гаргавал тэрхүү зээлдэгч байгууллагын хувьцааг үнэгүй эсвэл маш бага үнээр (“өмчийн урамшуулал”) авах нөхцөлтэйгээр зээл олгохыг зарим үед зөвшөөрдөг. Өмчийн урамшууллын шинжийн улмаас уг тэргүүн бус ээлжийн эрхтэй зээлийн хүү нь бусад тохиолдолд тогтоогдох байсан түвшнээс бага хүүтэй байдаг. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх байдлаар уг тэргүүн бус ээлжийн эрхтэй зээлийг бодит үнэ цэнээр хэмждэггүй (УСНББОУС 29-ийн 12(в) параграф) гэж үзвэл хэдийгээр тухайн зээлдэгч хөрөнгийн биржид хувьцаагаа арилжих эсэхээс болзошгүй хамаарах боловч уг өмчийн урамшууллын шинж нь дагалдах үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолтыг хангах уу?**

Тийм. Өмчийн өгөөжийн эдийн засгийн шинж чанар ба эрсдэл нь өрийн үндсэн хэрэглүүрийн эдийн засгийн шинж чанар, эрсдэлтэй нягт уялдаа холбоогүй байна (УСНББОУС 29-ийн 12(а) параграф). Өмчийн урамшуулал нь тухайн зээлдэгчийн хувьцааны үнийн өөрчлөлтөөс хамааран өөрчлөгдөх үнэ цэнэтэй ба зах зээлийн хүчин зүйлсийн өөрчөлтөд ижил төсөөтэй хариу үзүүлэхээр хүлээгдэж буй бусад төрлийн гэрээний хувьд шаардахаас бага хэмжээний анхны цэвэр хөрөнгө оруулалтыг шаардана эсвэл анхны цэвэр хөрөнгө оруулалтыг шаардахгүй бөгөөд түүнийг ирээдүйд барагдуулах учраас энэ нь дагалдах үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолтыг хангана (УСНББОУС 29-ийн 12(б) параграф ба УСНББОУС 29-ийн 10(а) параграф). Хэдийгээр хувьцаа авах эрх нь тухайн зээлдэгч ирээдүйд хувьцаагаа биржид гаргах эсэхээс болзошгүй хамаарах боловч уг өмчийн урамшууллын шинж нь дагалдах үүсмэл хэрэглүүрийн тодорхойлолтыг хангана. Үүсмэл хэрэглүүр нь нэрлэсэн дүнтэй хамааралгүй ирээдүйн зарим үйл явдлын үр дүнд өөрчлөгдөж болох төлбөрийг шаарддаг гэж УСНББОУС 29-ийн МЗУ21-р параграфт заасан. Өмчийн урамшууллын шинж нь тогтмол төлбөрийн эрхгүй байхаас бусдаар ийм үүсмэл хэрэглүүртэй ижил төсөөтэй бөгөөд хэрэв ирээдүйн үйл явдал гарч тохиолдвол опционы эрх олгодог.



**В.5** *Дагалдах үүсмэл хэрэглүүр: Өрийн эсвэл өмчийн хэрэглүүрүүдийг үндсэн гэрээ гэж тодорхойлох*

**А** байгууллага нь **Б** байгууллагын гаргасан 1 сая ТН-ийн үндсэн дүнтэй, таван жилийн хугацаатай бөгөөд **В** байгууллагын хувьцааны үнээр индексжүүлсэн “өр”-ийн хэрэглүүрийг худалдан авсан. Дуусгавар болох үед **А** байгууллага нь **Б** байгууллагаас үндсэн дүн дээр **В** байгууллагын 10,000 ширхэг хувьцааны бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нэмсэн эсвэл хассан дүнг хүлээн авна. Хувьцааны одоогийн үнэ нь 110ТН байна. **Б** байгууллага нь тусдаа хүүний төлбөр төлөхгүй. Худалдан авалтын үнэ нь 1 сая ТН юм. **А** байгууллага нь уг өрийн хэрэглүүрийг борлуулах боломжтой гэж ангилсан. Өмчтэй индексжүүлсэн үндсэн дүнтэй учраас **А** байгууллага нь уг хэрэглүүрийг дагалдах үүсмэл хэрэглүүр бүхий холимог хэрэглүүр гэж үзсэн. Дагалдах үүсмэл хэрэглүүрийг салган тусгаарлах зорилгын хувьд уг үндсэн гэрээ нь өмчийн хэрэглүүр үү эсвэл өрийн хэрэглүүр үү?

Уг холимог хэрэглүүр нь тогтсон дуусгавар хугацаатай, өөрөөр хэлбэл өмчийн хэрэглүүрийн тодорхойлолтыг хангахгүй учраас үндсэн гэрээ нь өрийн хэрэглүүр болно (УСНББОУС 28-ын 9-р параграф ба УСНББОУС 28-ын 14-р параграф). Үүнийг тэг купонтой өрийн хэрэглүүр гэж тайлагнана. Иймээс үндсэн гэрээг тайлагнахдаа, **А** байгууллага нь анх хүлээн зөвшөөрөх үеийн холбогдох зах зээлийн хүүний түвшинг ашигласнаар уг 1 сая ТН-д хамаарах хүүг таван жилийн хугацаанд хуваарилан тооцно. Опцион бус дагалдах үүсмэл хэрэглүүрийн анхны бодит үнэ цэнэ тэг байхуйцаар түүнийг салган тусгаарлана (Асуулт В.1-ийг үзнэ үү).

**В.6** *Дагалдах үүсмэл хэрэглүүр: Зохиомол хэрэглүүр*

**А** байгууллага нь **Б** байгууллагын гаргасан таван жилийн хугацаатай, хөвөх хүүтэй өрийн хэрэглүүрийг худалдан авсан. Үүний хамтаар **А** байгууллага нь таван жилийн хугацаатай, хувьсах хүү-төлөх ба тогтмол хүү-хүлээн авах хүүний түвшний свопын гэрээг **В** байгууллагатай байгуулсан. **А** байгууллага нь өрийн хэрэглүүр ба свопын хослолыг тогтмол хүүтэй зохиомол хэрэглүүр гэж үзсэн бөгөөд түүнийг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших эерэг санаа зорилготой ба чадвар боломжтой учраас уг хэрэглүүрийг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт гэж ангилсан. Хэрэв үүсмэл хэрэглүүр нь өрийн үндсэн гэрээний дагуу төлөх эсвэл хүлээн авах хүүний дүнг өөрчилж чадах хүүний түвшинтэй уялдсан бол уг дагалдах үүсмэл хэрэглүүрийг түүний үндсэн хэрэглүүрийн хамт ангилахыг УСНББОУС 29-ийн МЗУ46(а) параграфтаар шаарддаг тул **А** байгууллага нь свопыг тусдаа тайлагнах нь тохиромжгүй гэж үзэж байна. Уг байгууллагын дүн шинжилгээ зөв үү?

Үгүй. Дагалдах үүсмэл хэрэглүүр нь уг үүсмэл бус үндсэн гэрээнд тусгагдсан нөхцөл ба болзол юм. УСНББОУС 29-ийг мөрдөх зорилгоор хоёр буюу хэд хэдэн тусдаа санхүүгийн хэрэглүүрүүдийг нэгдсэн нэг хэрэглүүр (“зохиомол хэрэглүүр”-ийн нягтлан бодох бүртгэл) гэж үзэх нь ерөнхийдөө тохиромжгүй байдаг. Санхүүгийн хэрэглүүр бүр нь өөрийн нөхцөл, болзолтой бөгөөд тэдгээрийг тус тусад нь шилжүүлж эсвэл барагдуулж болох юм. Иймээс өрийн хэрэглүүр ба свопыг тусад нь ангилна. Энд дурдсан ажил гүйлгээ нь Асуулт Б.5-д авч хэлэлцсэн,

уг үр дүн болох хүүний түвшний свопоос тусдаа мөн чанаргүй ажил гүйлгээнээс өөр юм.

*В.7 Дагалдах үүсмэл хэрэглүүр: Гадаад валютаарх хэрэглүүрийн худалдан авалт ба борлуулалтын гэрээ*

**Нийлүүлэлтийн гэрээ нь (а) тухайн гэрээний аль нэг үндсэн оролцогч талын бүртгэлийн валют, (б) худалдан авах буюу нийлүүлэх уг холбогдох бараа, үйлчилгээний үнийг дэлхий дахинд хийгдэж буй худалдаа арилжаанд түгээмэл илэрхийлдэг валют, (в) тухайн ажил гүйлгээ хийгдэж буй эдийн засгийн орчинд санхүүгийн бус зүйлсийг худалдан авах буюу борлуулах гэрээнүүдэд нийтлэг ашигладаг валютаас бусад валютаар төлбөрийг хийдэг. УСНББОУС 29-ийн дагуу салган тусгаарлах хэрэгтэй дагалдах үүсмэл хэрэглүүр байна уу?**

Тийм. Үлгэрчлэн харуулвал: Норвегийн байгууллага нь Франц дахь байгууллагад газрын тос худалдахыг зөвшөөрчээ. Хэдийгээр газрын тосны гэрээг дэлхий дахинд хийгдэж буй худалдаа арилжаанд ихэвчлэн ам доллараар илэрхийлдэг бөгөөд Норвеги улсад санхүүгийн бус зүйлсийг худалдан авах буюу борлуулах гэрээнд Норвегийн кроньг нийтлэг ашигладаг боловч уг газрын тосны гэрээг швейцар франкаар илэрхийлсэн. Аль ч байгууллага нь швейцар франкаар мэдэгдэхүйц их үйл ажиллагаа эрхлэн явуулдаггүй. Энэ тохиолдолд Норвегийн байгууллага нь уг нийлүүлэлтийн гэрээг швейцар франк худалдан авах гадаад валютын дагалдах форвард бүхий үндсэн гэрээ гэж үзнэ. Францын байгууллага нь уг нийлүүлэлтийн гэрээг швейцар франк худалдах гадаад валютын дагалдах форвард бүхий үндсэн гэрээ гэж үзнэ. Тухайн тайлагнагч байгууллага нь хэрэв тохиромжтой бол үүнийг мөнгөн гүйлгээний хейжийн хэрэглүүр гэж сонгосноос бусад тохиолдолд байгууллага бүр нь уг валютын форвардын бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд тусгана.

*В.8 Гадаад валютын дагалдах үүсмэл хэрэглүүр: Холбоо хамааралгүй гадаад валютын нөхцөл*

**Санхүүгийн тайлангийн зүйлсийг еврод (түүний бүртгэлийн валют) үндэслэн санхүүгийн тайландаа хэмждэг А байгууллага нь газрын тосыг зургаан сарын дараа 1,000 ам доллараар худалдан авах гэрээг Б байгууллагатай байгуулсан. Тус Б байгууллагын бүртгэлийн валют нь Норвегийн крон юм. Уг газрын тосны үндсэн гэрээг тухайн байгууллагын хүлээгдэж буй худалдан авалт, борлуулалт буюу ашиглалтын шаардлагуудын дагуу (УСНББОУС 29-ийн 4-р параграф ба УСНББОУС 29-ийн МЗУ22-р параграф) санхүүгийн бус зүйлийг нийлүүлэх зорилгоор байгуулсан бөгөөд тэр хэвээр эзэмшиж байгаа тул энэ нь УСНББОУС 29-ийн цар хүрээнд хамаарахгүй. Газрын тосны нийлүүлэлт ба төлбөрөөс гадна талууд нь ам доллар ба Норвегийн кроны ханшийн хэлбэлзлийг уг 100,000 ам долларын нэрлэсэн дүнгээр үржүүлсэнтэй тэнцүү дүнг харилцан нөхөн олгоно гэж заасан гадаад валютын ханшийн хөшүүргийн нөхцлийг тэрхүү газрын тосны гэрээнд тусгасан. Уг дагалдах үүсмэл хэрэглүүрийг (гадаад валютын ханшийн хөшүүргийн нөхцлийг) УСНББОУС 29-ийн 12-р параграфын дагуу тэрхүү газрын тосны үндсэн гэрээтэй нягт уялдаатай гэж үзэх үү?**

Үгүй. Хөшүүрэгдсэн гадаад валютын ханшийн нөхцөл нь тэрхүү газрын тосны үндсэн гэрээтэй нягт холбоогүй учраас түүнийг уг газрын тосны үндсэн гэрээнээс салган тусгаарлана (УСНББОУС 29-ийн МЗУ46(г) параграф).

Ам доллар нь А ба Б байгууллагын аль алины бүртгэлийн валют биш учраас 1,000 ам долларын дүн бүхий уг газрын тосны үндсэн гэрээний төлбөрийн нөхцлийг гадаад валютын үүсмэл хэрэглүүр гэж үзэж болно. Төлбөрийг ам доллараар хийхийг шаарддаг түүхий газрын тосны гэрээг УСНББОУС 29-ийн МЗУ45(г) параграфын дагуу гадаад валютын үүсмэл хэрэглүүр бүхий үндсэн гэрээ гэж үзэхгүй учраас энэхүү гадаад валютын үүсмэл хэрэглүүрийг салган тусгаарлахгүй.

Хөшүүрэгдсэн гадаад валютын ханшийн нөхцөл нь тухайн газрын тосны ажил гүйлгээний хувьд шаардлагатай төлбөрөөс гадна ам доллар ба Норвегийн кроны ханшийн хэлбэлзлийг уг 100,000 ам долларын нэрлэсэн дүнгээр үржүүлсэнтэй тэнцүү дүнг талууд харилцан нөхөн олгоно гэж заасан. Энэ нь газрын тосны үндсэн гэрээтэй холбоо хамааралгүй учраас үүнийг уг газрын тосны үндсэн гэрээнээс салган тусгаарлаж, УСНББОУС 29-ийн 12-р параграфын дагуу дагалдах үүсмэл хэрэглүүр гэж тайлагнана.

*В.9 Гадаад валютын дагалдах үүсмэл хэрэглүүр: Олон улсын худалдааны валют*

**УСНББОУС 29-ийн МЗУ46(г) параграф нь холбогдох бараа, үйлчилгээний үнийг дэлхий дахинд хийгдэж буй худалдаа арилжаанд түгээмэл илэрхийлдэг валют гэж заасан. Тухайн гэрээний оролцогч үндсэн талуудын аль нэгний орон нутгийн хүрээнд худалдаа арилжаа хийгдэж буй зарим бүтээгдэхүүн, үйлчилгээний хувьд ашигладаг валют байж болох уу?**

Үгүй. Холбогдох бараа, үйлчилгээний үнийг дэлхий дахинд хийгдэж буй худалдаа арилжаанд түгээмэл илэрхийлдэг валют нь зөвхөн нэг орон нутагт төдийгүй дэлхий дахинд хийгдэж буй ижил төсөвтэй ажил гүйлгээнд ашиглах цорын ганц валют юм. Жишээлбэл; Хойд Америк дахь байгалийн хийн улс дамнасан ажил гүйлгээг ихэвчлэн ам доллараар илэрхийлдэг ба ийм ажил гүйлгээг Европт ихэвчлэн еврогоор илэрхийлдэг бол ам доллар ба евроны аль аль нь дэлхий дахинд хийгдэж буй худалдаа арилжаанд тухайн бараа, үйлчилгээг түгээмэл илэрхийлдэг валют биш юм.

*В.10 Дагалдах үүсмэл хэрэглүүр: Өөрийн хүлээн зөвшөөрсөн бараг бүх хөрөнгө оруулалтыг нөхөхгүйгээр барагдуулахыг эзэмшигчид зөвшөөрдөг боловч түүнээс заавал шаардахгүй*

**Хэрэв нэгдсэн хэрэглүүрийн нөхцөл нь өөрийн хүлээн зөвшөөрсөн бараг бүх хөрөнгө оруулалтыг нөхөхгүй байхад хүргэх тийм байдлаар уг нэгдсэн хэрэглүүрийг барагдуулахыг эзэмшигчид зөвшөөрдөг боловч түүнээс заавал шаарддаггүй бөгөөд гаргагч нь ийм эрхгүй бол (жишээлбэл; буцаах эрхтэй өөрийн хэрэглүүр) тухайн гэрээ нь эзэмшигч өөрийн хүлээн зөвшөөрсөн бараг бүх хөрөнгө оруулалтыг нөхөхгүй байх гэсэн УСНББОУС 29-ийн МЗУ46(а) параграфт заасан нөхцлийг хангах уу?**

Үгүй. Хэрэв нэгдсэн хэрэглүүрийн нөхцөл нь өөрийн хүлээн зөвшөөрсөн бараг бүх хөрөнгө оруулалтыг нөхөхгүй байхад хүргэх тийм байдлаар уг нэгдсэн хэрэглүүрийг барагдуулахыг хөрөнгө оруулагчид зөвшөөрдөг боловч түүнээс заавал шаарддаггүй бөгөөд гаргагч нь ийм эрхгүй бол “эзэмшигч өөрийн хүлээн зөвшөөрсөн бараг бүх хөрөнгө оруулалтыг нөхөхгүй байх” гэсэн нөхцөл хангагдахгүй. Иймээс ийм нөхцөлтэй ба хүүний түвшний дагалдах үүсмэл хэрэглүүр бүхий хүүтэй үндсэн гэрээг тухайн үндсэн гэрээтэйгээ нягт уялдаа холбоотой гэж үзнэ. Эзэмшигч өөрийн хүлээн зөвшөөрсөн бараг бүх хөрөнгө оруулалтыг нөхөхгүй байхад хүргэх тийм дүнгээр барагдуулахыг тэрхүү эзэмшигч хүлээн зөвшөөрөхөд албадан хүргэх тийм нөхцөл байдлын хувьд “эзэмшигч өөрийн хүлээн зөвшөөрсөн бараг бүх хөрөнгө оруулалтыг нөхөхгүй байх” гэсэн нөхцлийг хэрэглэдэг.

*В.11 Дагалдах үүсмэл хэрэглүүр: Бодит үнэ цэнийг найдвартай тодорхойлох*

**Бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжиж чадахгүй ба биржид арилждаггүй тийм өмчийн хэрэглүүрээр барагдуулдаг учраас уг салган тусгаарлах шаардлагатай дагалдах үүсмэл хэрэглүүрийг найдвартай хэмжих боломжгүй бол тэрхүү дагалдах үүсмэл хэрэглүүрийг өртгөөр нь хэмжих үү?**

Үгүй. Энэ тохиолдолд уг нэгдсэн хэрэглүүрийг бүхэлд нь худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүр гэж үзнэ (УСНББОУС 29-ийн 14-р параграф). Хэрэв нэгдсэн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадах бол уг нэгдсэн гэрээг бодит үнэ цэнээр нь хэмжинэ. Гэвч тухайн нэгдсэн хэрэглүүрийн өмчийн бүрэлдэхүүн хэсэг нь бүхэлдээ уг хэрэглүүрийн талаархи найдвартай тооцооллыг олж авахад саад учруулахуйц хангалттай том дүнтэй байж болно гэж тэрхүү байгууллага дүгнэж болох юм. Ийм тохиолдолд уг нэгдсэн хэрэглүүрийг өртгөөс үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр хэмжинэ.

## **Хэсэг Г: Хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлт**

*Г.1 Анхны хүлээн зөвшөөрөлт*

**Г.1.1 Хүлээн зөвшөөрөлт: Мөнгөн барьцаа**

**Б байгууллага нь А байгууллагатай хийсэн өөр нэг ажил гүйлгээний (жишээлбэл; үнэт цаас зээлдүүлэх ажил гүйлгээ) барьцаа болгон уг А байгууллагад мөнгө шилжүүлсэн. Тэрхүү мөнгийг А байгууллагын хөрөнгөөс хууль ёсоор салгаж тусгаарлаагүй. А байгууллага нь хөрөнгө хүлээн авсан мэтээр уг мөнгөн барьцааг хүлээн зөвшөөрөх үү?**

Тийм. Санхүүгийн хөрөнгийн эцсийн хэрэгжилт нь түүнийг мөнгөнд хөрвүүлэх явдал бөгөөд иймээс Б байгууллагын шилжүүлсэн мөнгөний эдийн засгийн үр өгөөжийг А байгууллага нь хүлээн зөвшөөрөхийн өмнө цаашид хувьсан өөрчлөлт хийх шаардлагагүй юм. Иймээс Б байгууллага нь мөнгийг үл хүлээн зөвшөөрч, А байгууллагаас авах авлагыг хүлээн зөвшөөрнө, харин А байгууллага нь тэрхүү мөнгийг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх ба Б байгууллагад төлөх өглөгийг хүлээн зөвшөөрнө.

Г.2 Санхүүгийн хөрөнгийн ердийн нөхцлөөр худалдан авалт буюу борлуулалт

Г.2.1 Арилжааны өдөр эсвэл барагдуулалтын өдөр: Худалдан авалтын хувьд бүртгэх дүн

**Энэ Стандарт дахь арилжааны өдрийн болон барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг санхүүгийн хөрөнгийн худалдан авалтад хэрхэн хэрэглэх вэ?**

Энэ Стандарт дахь арилжааны өдрийн болон барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг санхүүгийн хөрөнгийн худалдан авалтад хэрхэн хэрэглэхийг дараах жишээнд үлгэрчлэн харуулав. 20X1 оны 12 дугаар сарын 29-нд байгууллага нь санхүүгийн хөрөнгийг 1,000ТН-ээр худалдан авах баталгаа гаргасан бөгөөд 1,000ТН нь түүний уг баталгааны (арилжааны) өдрөөрх бодит үнэ цэнэ юм. Ажил гүйлгээний зардал нь материаллаг бус байсан. Тухайн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь 20X1 оны 12 дугаар сарын 31-нд (санхүүгийн жилийн эцэст) 1,002ТН, 20X2 оны 01 дүгээр сарын 04-нд (барагдуулалтын өдөр) 1,003ТН байв. Доорх хоёр хүснэгтэд харуулсанчлан, тухайн хөрөнгийн хувьд бүртгэх дүн нь түүнийг хэрхэн ангилсан ба арилжааны өдрийн эсвэл барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийг ашигласан эсэхээс хамаарна.

<b>Барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэл</b>			
	<b>Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт</b>	<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн хамтаар бодит үнэ цэнээр дахин хэмжсэн борлуулах боломжтой хөрөнгө</b>	<b>Ашиг, алдагдлын өөрчлөлтийн хамтаар бодит үнэ цэнээр дахин хэмжсэн, ашиг алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг хөрөнгө</b>
<b>Үлдэгдэл</b>			
<b>20X1 оны 12-р сарын 29</b>			
Санхүүгийн хөрөнгө	-	-	-
Санхүүгийн өр төлбөр	-	-	-
<b>20X1 оны 12-р сарын 31</b>			
Авлага	-	2	2
Санхүүгийн хөрөнгө	-	-	-
Санхүүгийн өр төлбөр	-	-	-
Цэвэр хөрөнгө/өмч (бодит үнэ цэнийн тохируулга)	-	(2)	-
Хуримтлагдсан ашиг, алдагдал (ашиг, алдагдлаар дамжуулан)	-	-	(2)

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

<b>20X2 оны 01-р сарын 04</b>			
Авлага	-	-	-
Санхүүгийн хөрөнгө	1,000	1,003	1,003
Санхүүгийн өр төлбөр	-	-	-
Цэвэр хөрөнгө/өмч (бодит үнэ цэнийн тохируулга)	-	(3)	-
Хуримтлагдсан ашиг, алдагдал (ашиг, алдагдлаар дамжуулан)	-	-	(3)

<b>Арилжааны өдрийн нягтлан бодох бүртгэл</b>			
<b>Үлдэгдэл</b>	<b>Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт</b>	<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн хамтаар бодит үнэ цэнээр дахин хэмжсэн борлуулах боломжтой хөрөнгө</b>	<b>Ашиг, алдагдлын өөрчлөлтийн хамтаар бодит үнэ цэнээр дахин хэмжсэн, ашиг алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг хөрөнгө</b>
<b>20X1 оны 12-р сарын 29</b>			
Санхүүгийн хөрөнгө	1,000	1,000	1,000
Санхүүгийн өр төлбөр	(1,000)	(1,000)	(1,000)
<b>20X1 оны 12-р сарын 31</b>			
Авлага	-	-	-
Санхүүгийн хөрөнгө	1,000	1,002	1,002
Санхүүгийн өр төлбөр	(1,000)	(1,000)	(1,000)
Цэвэр хөрөнгө/өмч (бодит үнэ цэнийн тохируулга)	-	(2)	-
Хуримтлагдсан ашиг, алдагдал (ашиг, алдагдлаар дамжуулан)	-	-	(2)
<b>20X2 оны 01-р сарын 04</b>			
Авлага	-	-	-
Санхүүгийн хөрөнгө	1,000	1,003	1,003
Санхүүгийн өр төлбөр	-	-	-
Цэвэр хөрөнгө/өмч (бодит үнэ цэнийн тохируулга)	-	(3)	-
Хуримтлагдсан ашиг, алдагдал (ашиг, алдагдлаар дамжуулан)	-	-	(3)

**Г.2.2 Арилжааны өдөр эсвэл барагдуулалтын өдөр: Борлуулалтын хувьд бүртгэх дүн**

**Энэ Стандарт дахь арилжааны өдрийн болон барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг санхүүгийн хөрөнгийн борлуулалтад хэрхэн хэрэглэх вэ?**

Энэ Стандарт дахь арилжааны өдрийн болон барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг санхүүгийн хөрөнгийн борлуулалтанд хэрхэн хэрэглэхийг дараах жишээнд үлгэрчлэн харуулав. 20X2 оны 12 дугаар сарын 29-нд (арилжааны өдөр) байгууллага нь санхүүгийн хөрөнгийг түүний 1,010ТН-ийн одоогийн бодит үнэ цэнээр борлуулах гэрээ байгуулсан. Уг хөрөнгийг нэг жилийн өмнө 1,000ТН-ээр худалдан авсан бөгөөд түүний хорогдуулсан өртөг нь 1,000ТН байсан. Тухайн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь 20X2 оны 12 дугаар сарын 31-нд (санхүүгийн жилийн эцэст) 1,012ТН байв. 20X3 оны 01 дүгээр сарын 04-нд (барагдуулалтын өдөр) бодит үнэ цэнэ нь 1,013ТН болсон. Доорх хоёр хүснэгтэд харуулсанчлан, тухайн хөрөнгийн хувьд бүртгэх дүн нь түүнийг хэрхэн ангилсан ба арилжааны өдрийн эсвэл барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийг ашигласан эсэхээс хамаарна (тухайн хөрөнгөнд хуримтлагдаж болох аливаа хүүг харгалзан үзээгүй болно).

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийн талаархи борлуулагчийн эрх нь арилжааны өдрөөр дуусгавар болдог учраас уг байгууллага нь барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэдэг боловч ердийн нөхцлөөр борлуулсан санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг арилжааны өдөр ба барагдуулалтын өдрийн хоорондох хугацаанд санхүүгийн тайланд бүртгэдэггүй.

<b>Барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэл</b>			
<b>Үлдэгдэл</b>	<b>Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт</b>	<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн хамтаар бодит үнэ цэнээр дахин хэмжсэн борлуулах боломжтой хөрөнгө</b>	<b>Ашиг, алдагдлын өөрчлөлтийн хамтаар бодит үнэ цэнээр дахин хэмжсэн, ашиг алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг хөрөнгө</b>
<b>20X2 оны 12-р сарын 29</b>			
Авлага	-	-	-
Санхүүгийн хөрөнгө	1,000	1,010	1,010
Цэвэр хөрөнгө/өмч (бодит үнэ цэнийн тохируулга)	-	10	-
Хуримтлагдсан ашиг, алдагдал (ашиг, алдагдлаар дамжуулан)	-	-	10
<b>20X2 оны 12-р сарын 31</b>			
Авлага	-	-	-
Санхүүгийн хөрөнгө	1,000	1,010	1,010

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

Цэвэр хөрөнгө/өмч (бодит үнэ цэнийн тохируулга)	-	10	-
Хуримтлагдсан ашиг, алдагдал (ашиг, алдагдлаар дамжуулан)	-	-	10
<b>20X3 оны 01-р сарын 04</b>			
Цэвэр хөрөнгө/өмч (бодит үнэ цэнийн тохируулга)	-	-	-
Хуримтлагдсан ашиг, алдагдал (ашиг, алдагдлаар дамжуулан)	10	10	10

<b>Арилжааны өдрийн нягтлан бодох бүртгэл</b>			
<b>Үлдэгдэл</b>	<b>Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт</b>	<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн хамтаар бодит үнэ цэнээр дахин хэмжсэн борлуулах боломжтой хөрөнгө</b>	<b>Ашиг, алдагдлын өөрчлөлтийн хамтаар бодит үнэ цэнээр дахин хэмжсэн, ашиг алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг хөрөнгө</b>
<b>20X2 оны 12-р сарын 29</b>			
Авлага	1,010	1,010	1,010
Санхүүгийн хөрөнгө	-	-	-
Цэвэр хөрөнгө/өмч (бодит үнэ цэнийн тохируулга)	-	-	-
Хуримтлагдсан ашиг, алдагдал (ашиг, алдагдлаар дамжуулан)	10	10	10
<b>20X2 оны 12-р сарын 31</b>			
Авлага	1,010	1,010	1,010
Санхүүгийн хөрөнгө	-	-	-
Цэвэр хөрөнгө/өмч (бодит үнэ цэнийн тохируулга)	-	-	-
Хуримтлагдсан ашиг, алдагдал (ашиг, алдагдлаар дамжуулан)	10	10	10
<b>20X3 оны 01-р сарын 04</b>			
Цэвэр хөрөнгө/өмч (бодит үнэ цэнийн тохируулга)	-	-	-
Хуримтлагдсан ашиг, алдагдал (ашиг, алдагдлаар дамжуулан)	10	10	10



**Г.2.3 Барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэл: Мөнгөн бус санхүүгийн хөрөнгийн солилцоо**

**Хэрэв байгууллага нь барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийг ашиглан санхүүгийн хөрөнгийн борлуулалтыг хүлээн зөвшөөрдөг бол борлуулсан мөнгөн бус санхүүгийн хөрөнгийн хариуд хүлээн авах санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг УСНББОУС 29-ийн 66-р параграфын дагуу хүлээн зөвшөөрөх үү?**

Нөхцөл байдлаас хамаарна. Хэрэв байгууллага нь санхүүгийн хөрөнгийн тухайн ангийн хувьд барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэдэг бол хүлээн авах санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн аливаа өөрчлөлтийг УСНББОУС 29-ийн 66-р параграфын дагуу тайлагнана. Харин байгууллага нь уг хүлээн авах санхүүгийн хөрөнгийг арилжааны өдрийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэдэг ангид хамааруулан ангилсан бол тэрхүү хүлээн авах хөрөнгийг УСНББОУС 29-ийн МЗУ70-р параграфт заасанчлан, арилжааны өдөр хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд байгууллага нь уг барагдуулалтын өдөр хүргэн нийлүүлэх тухайн санхүүгийн хөрөнгийн дансны үнэтэй тэнцүү дүнгээр өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

Үлгэрчлэн харуулвал: 20Х2 оны 12 дугаар сарын 29-нд (арилжааны өдөр) А байгууллага нь худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж ангилж, бодит үнэ цэнээр хэмждэг Б бондын хариуд хорогдуулсан өртгөөр бүртгэдэг А авлагын бичиг борлуулах гэрээ байгуулсан. 12 дугаар сарын 29-нд хоёр хөрөнгийн аль алины бодит үнэ цэнэ нь 1,010ТН, харин А авлагын бичгийн хорогдуулсан өртөг нь 1,000ТН байсан. А байгууллага нь зээл ба авлагын хувьд барагдуулалтын өдрийн нягтлан бодох бүртгэлийг, худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй хөрөнгийн хувьд арилжааны өдрийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэдэг. 20Х2 оны 12 дугаар сарын 31-нд (санхүүгийн жилийн эцэст) А авлагын бичгийн бодит үнэ цэнэ нь 1,012ТН, Б бондын бодит үнэ цэнэ нь 1,009ТН болсон. 20Х3 оны 01 дүгээр сарын 04-нд А авлагын бичгийн бодит үнэ цэнэ нь 1,013ТН, Б бондын бодит үнэ цэнэ нь 1,007ТН байв. Дараах журналын бичилтийг хийнэ:

<b>20Х2 оны 12 дугаар сарын 29</b>			
Дебит	Б бонд	1,010ТН	
Кредит	Өглөг		1,010ТН
<b>20Х2 оны 12 дугаар сарын 31</b>			
Дебит	Арилжааны гарз	1ТН	
Кредит	Б бонд		1ТН
<b>20Х3 оны 01 дүгээр сарын 04</b>			
Дебит	Өглөг	1,010ТН	
Дебит	Арилжааны гарз	2ТН	
Кредит	А авлагын бичиг		1,000ТН
Кредит	Б бонд		2ТН
Кредит	Хэрэгжүүлэлтийн олз		10ТН

## **Хэсэг Д: Хэмжилт**

### **Д.1 Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн анхны хэмжилт**

#### **Д.1.1 Анхны хэмжилт: Ажил гүйлгээний зардал**

**Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэнээс бусад санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн анхны хэмжилтэнд ажил гүйлгээний зардлыг оруулна. Энэ шаардлагыг практикт хэрхэн мөрдөх вэ?**

Санхүүгийн хөрөнгийн хувьд, хөрөнгийн олж эзэмшилтэнд шууд хамаарах өсөн нэмэгдэх зардал, тухайлбал, шимтгэл ба хураамжийг анх хүлээн зөвшөөрсөн дүн дээр нэмнэ. Санхүүгийн өр төлбөрийн хувьд, өрийг гаргахтай шууд холбоотой зардлыг тухайн өрийн анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс хасна. Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмждэг санхүүгийн хэрэглүүрийн хувьд, ажил гүйлгээний зардлыг анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнийн хэмжилт дээр нэмэхгүй.

Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт, зээл ба авлага гэх мэт хорогдуулсан өртгөөр бүртгэдэг санхүүгийн хэрэглүүр болон ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр бүртгэдэггүй санхүүгийн өр төлбөрийн хувьд, ажил гүйлгээний зардлыг үр ашигт хүүний арга ашиглан тооцоолсон, хорогдуулсан өртөгт тусган оруулах бөгөөд ингэснээр тухайн хэрэглүүрийн хугацааны туршид ашиг, алдагдалд шингээж хорогдуулна.

Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгийн хувьд, ажил гүйлгээний зардлыг уг дараагийн дахин хэмжилтийн өдрөөрх бодит үнэ цэнийн өөрчлөлтийн нэг хэсэг байдлаар бусад цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө. Хэрэв борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө нь тогтмол буюу тодорхойлж болох төлбөрүүдтэй ба тодорхойгүй хугацаатай биш бол ажил гүйлгээний зардлыг үр ашигт хүүний арга ашиглан ашиг, алдагдалд шингээж хорогдуулна. Хэрэв борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө нь тогтмол буюу тодорхойлж болох төлбөрүүдгүй ба тодорхойгүй хугацаатай бол тухайн хөрөнгийг хүлээн зөвшөөрсөн эсвэл үнэ цэнэ буурсан үед ажил гүйлгээний зардлыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийн шилжүүлэлт эсвэл данснаас хасалтын хувьд гарахаар хүлээгдэж буй ажил гүйлгээний зардлыг тухайн санхүүгийн хэрэглүүрийн хэмжилтэнд тусган оруулахгүй.

### **Д.2 Бодит үнэ цэнийн хэмжилтийн анхаарах зүйлс**

#### **Д.2.1 Хөрөнгө оруулалтын санд хамаарах бодит үнэ цэнийн хэмжилтийн анхаарах зүйлс**

**Эзэмшиж буй хөрөнгийн бодит үнэ цэнийг хэмжихэд ашигладаг тохиромжтой үнэ нь ихэвчлэн одоогийн санал болгосон худалдан авах үнэ байдаг гэдгийг УСНББОУС 29-ийн МЗУ104-р параграфт заасан. Зарим хөрөнгө оруулалтын санд мөрдөх дүрэм нь цэвэр хөрөнгийн үнэ цэнийг тухайн зах зээлийн дундаж үнэд үндэслэн хөрөнгө оруулагчдад тайлагнахыг шаарддаг. Ийм**

**нөхцөлд зах зээлийн дундаж үнэд үндэслэн түүний хөрөнгийг хэмжих нь хөрөнгө оруулалтын сангийн хувьд тохиромжтой юу?**

Үгүй. Тодорхой зорилгын хувьд өөр өөр хэмжилт ашиглахыг шаардсан зохицуулалттай байх нь харгалзах өр төлбөргүй үед одоогийн санал болгосон худалдан авах үнэ ашиглах талаархи УСНББОУС 29-ийн МЗУ104-р параграфын ерөнхий шаардлагуудаас гажихыг зөвтгөн батлахгүй. Хөрөнгө оруулалтын сан нь хөрөнгөө өөрийн санхүүгийн тайландаа одоогийн санал болгосон худалдан авах үнээр хэмжинэ. Өөрийн цэвэр хөрөнгийн үнэ цэнийг хөрөнгө оруулагч нартаа тайлагнахдаа, хөрөнгө оруулалтын сан нь санхүүгийн байдлын тайландаа хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэнэ ба цэвэр хөрөнгийн үнэ цэнийн тооцоололд ашигласан үнэ хоорондох тохируулгын тайланг бэлтгэн харуулахыг хүсэж болох юм.

**Д.2.2 Бодит үнэ цэнийн хэмжилт: Том эзэмшилт**

**А байгууллага нь Б байгууллагын хувьцаат капиталын 15 хувийг эзэмшдэг. Уг хувьцааг идэвхитэй зах зээлд олон нийтэд арилжаалдаг. Одоогийн жишиг үнэ нь 100ТН байна. Өдрийн арилжааны хэмжээ нь эргэлтэнд байгаа хувьцааны 0.1 хувь юм. А байгууллага өөрийн өмчилж буй Б байгууллагын хувьцааг хэрэв багцалж борлуулвал түүний бодит үнэ цэнэ нь жишиг зах зээлийн үнээс илүү болно гэж А байгууллага үзэж байна. А байгууллага нь хувьцааны өөрийн эзэмшилтийг борлуулснаар олж болох үнийн талаар хараат бус хэд хэдэн тооцоолол хийлгэсэн. А байгууллага нь 105ТН-ээр борлуулж, өөрөөр хэлбэл жишиг үнээс 5 хувиар илүү урамшуулал олж авч чадна гэдгийг эдгээр тооцоолол харуулж байна. А байгууллага нь өөрийн хувьцааны эзэмшилтийг бодит үнэ цэнээр хэмжихдээ аль дүнг ашиглах хэрэгтэй вэ?**

УСНББОУС 29-ийн МЗУ103-р параграфт заасанчлан, идэвхитэй зах зээлд хэвлэн нийтэлсэн үнийн жишиг нь бодит үнэ цэнийн хамгийн сайн тооцоолол байдаг. Иймээс А байгууллага нь уг хэвлэн нийтэлсэн жишиг үнийг (100ТН) ашиглана. Хувьцааны эзэмшилтээ багцаар борлуулснаар А байгууллага нь илүү өндөр (эсвэл бага) үнийг олж авна гэдгийг хараат бус тооцоолол илтгэн харуулж байгаа гэсэн ганцхан шалтгааны улмаас А байгууллага нь жишиг зах зээлийн үнийг хэрэглэхгүй байж болохгүй.

**Д.3 Олз ба гарз**

**Д.3.1 Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө: Хувьцааны солилцоо**

**А байгууллага нь Б байгууллагын цөөн тооны хувьцааг эзэмшдэг. Уг хувьцааг борлуулах боломжтой гэж ангилсан. 20X0 оны 12 сарын 20-нд хувьцааны бодит үнэ цэнэ нь 120ТН ба цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан олз нь 20ТН байсан. Мөн тэр өдөр В байгууллага нь Б байгууллагыг худалдан авсан. Үүний үр дүнд А байгууллага нь Б байгууллагад эзэмшиж байсан хувьцааныхаа хариуд түүний бодит үнэ цэнэтэй тэнцүү хэмжээний В байгууллагын хувьцааг хүлээн авсан. УСНББОУС 29-ийн 64(б) параграфын дагуу А байгууллага нь цэвэр**

**хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн байсан 20ТН-ийн хуримтлагдсан олзыг ашиг, алдагдал руу дахин ангилах ёстой юу?**

Тийм. Уг ажил гүйлгээ нь УСНББОУС 29-д заасан үл хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангана. Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгөнд хамаарах ба цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан олз буюу гарзыг тухайн хөрөнгийг нь үл хүлээн зөвшөөрсөн үед ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөхийг УСНББОУС 29-ийн 64(б) параграфээр шаардсан байаг. Хувьцааны солилцоогоор А байгууллага нь Б байгууллагад өмчилж байсан хувьцаагаа данснаас хасаж, В байгууллагын хувьцааг хүлээн авсан.

**Д.3.2 УСНББОУС 29 ба УСНББОУС 4 - Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө: Валютын бүрэлдэхүүн хэсгийн салган тусгаарлалт**

**Борлуулах боломжтой мөнгөн зүйлсийн санхүүгийн хөрөнгийн хувьд, байгууллага нь гадаад валютын ханшийн өөрчлөлттэй холбоотой дансны үнийн өөрчлөлтийг УСНББОУС 4-ийн 27(а) ба УСНББОУС 4-ийн 32-р параграфын дагуу ашиг алдагдалд, харин дансны үнийн бусад өөрчлөлтийг УСНББОУС 29-ийн дагуу цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө. Цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан олз, гарзыг хэрхэн тодорхойлох вэ?**

Энэ нь тухайн тайлагнагч байгууллагын бүртгэлийн валютаар илэрхийлэгдсэн борлуулах боломжтой мөнгөн зүйлсийн санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртөг (хэрэв байгаа бол үнэ цэнийн бууралтаар тохируулсан) ба бодит үнэ цэнэ хоорондох зөрүү юм. УСНББОУС 4-ийн 32-р параграфыг мөрдөх зорилгын хувьд тухайн хөрөнгийг гадаад валютаар илэрхийлсэн хорогдуулсан өртгөөр хэмжсэн хөрөнгө гэж үзнэ.

Үлгэрчлэн харуулвал: 20Х1 оны 12 дугаар сарын 31-нд А байгууллага нь гадаад валютаар (ГВ) илэрхийлэгдсэн бондыг түүний бодит үнэ цэнэ болох 1,000 ГВ-аар худалдан авсан. Бонд нь дуусгавар болох хүртэл 5 жилийн үлдсэн хугацаатай, 1,250 ГВ-ын үндсэн дүнтэй, жил бүр төлөгдөх 4.7 хувийн тогтмол хүүтэй (1,250 ГВ х 4.7 хувь = жилд 59 ГВ) бөгөөд үр ашигт хүүний түвшин нь 10 хувь байсан. А байгууллага нь бондыг борлуулах боломжтой гэж ангилсан учраас олз, гарзыг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрдөг. Уг байгууллагын бүртгэлийн валют нь орон нутгийн валют (ОНВ) юм. 1 ГВ-ын ханш нь 1.5 ОНВ ба бондын дансны үнэ нь 1,500 ОНВ (=1,000 ГВ х 1.5) байсан.

Дебит	Бонд	1,500 ОНВ	
Кредит	Мөнгө		1,500 ОНВ

20Х2 оны 12 сарын 31-нд гадаад валютын ханш өсөж, 1 ГВ нь 2 ОНВ болсон. Бондын бодит үнэ цэнэ нь 1,060 ГВ тул дансны үнэ нь 2,120 ОНВ (=1,060 ГВ х 2) болно. Хорогдуулсан өртөг нь 1,041 ГВ (=2,082 ОНВ) байна. Энэ тохиолдолд цэвэр хөрөнгө/өмчид хуримтлуулж, хүлээн зөвшөөрөх тухайн хуримтлагдсан олз буюу гарз нь 20Х2 оны 12 дугаар сарын 31-нээрх бодит үнэ цэнэ ба хорогдуулсан өртгийн зөрүү, өөрөөр хэлбэл 38 ОНВ (=2,120 ОНВ-2,082 ОНВ) байна.

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

20X2 оны 12 дугаар сарын 31-нд уг бондын хувьд хүлээн авсан хүү нь 59 ГВ (=118 ОНВ) байв. Үр ашигт хүүний аргын дагуу тодорхойлсон хүүний орлого нь 100 ГВ (=1,000 x 10 хувь) байна. Тухайн жилд 1 ГВ-ын дундаж ханш нь 1.75 ОНВ байсан. Энэ асуултын зорилгын хувьд, дундаж ханшийг ашиглах нь тухайн жилийн туршид хүүний орлогыг хуримтлуулахад хэрэглэх спот ханшийн найдвартай, ойролцоо тооцоолол болно гэж төсөөлнө (УСНББОУС 4-ийн 25-р параграф). Иймээс тайлагнасан хүүний орлого нь 175 ОНВ (=100 ГВ x 1.75) болно. Үүнд 72 ОНВ-ын (= [100 ГВ–59 ГВ] x 1.75) анхны хөнгөлөлт багтсан болно. Иймээс уг бондын ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн ханшийн зөрүү нь 510 ОНВ (=2,082 ОНВ-1,500 ОНВ-172 ОНВ) байна. Мөн тухайн жилийн хувьд хүүний авлагад хамаарах ханшийн олз нь 15 ОНВ (=59 ГВ x [2.00–1.75]) байв.

Дебит	Бонд	620 ОНВ
Дебит	Мөнгө	118 ОНВ
Кредит	Хүүний орлого	175 ОНВ
Кредит	Ханшийн олз	525 ОНВ
Кредит	Цэвэр хөрөнгө/өмч дэх бодит үнэ цэнийн өөрчлөлт	38 ОНВ

20X3 оны 12 сарын 31-нд гадаад валютын ханш өсөж, 1 ГВ нь 2.50 ОНВ болсон. Бондын бодит үнэ цэнэ нь 1,070 ГВ тул дансны үнэ нь 2,675 ОНВ (=1,070 ГВ x 2) болно. Хорогдуулсан өртөг нь 1,086 ГВ (=2,715 ОНВ) байна. Хорогдуулсан өртөг нь 1,086 ГВ(=2,715 ОНВ) байна. Цэвэр хөрөнгө/өмчид хуримтлуулж, хүлээн зөвшөөрөх тухайн хуримтлагдсан олз буюу гарз нь 20X3 оны 12 дугаар сарын 31-нээрх бодит үнэ цэнэ ба хорогдуулсан өртгийн зөрүү, өөрөөр хэлбэл хасах 40 ОНВ (=2,675 ОНВ-2,715 ОНВ) байна. Иймээс цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн дүн нь 20X3 он дахь тухайн зөрүүгийн өөрчлөлт болох 78 ОНВ (=40 ОНВ+38 ОНВ)-тай тэнцүү байна.

20X3 оны 12 дугаар сарын 31-нд уг бондын хувьд хүлээн авсан хүү нь 59 ГВ (=148 ОНВ) байв. Үр ашигт хүүний аргын дагуу тодорхойлсон хүүний орлого нь 104 ГВ (=1,041 x 10 хувь) байна. Тухайн жилд 1 ГВ-ын дундаж ханш нь 2.25 ОНВ байсан. Энэ асуултын зорилгын хувьд, дундаж ханшийг ашиглах нь тухайн жилийн туршид хүүний орлогыг хуримтлуулахад хэрэглэх спот ханшийн найдвартай, ойролцоо тооцоолол болно гэж төсөөлнө (УСНББОУС 4-ийн 25-р параграф). Иймээс хүлээн зөвшөөрсөн хүүний орлого нь 234 ОНВ (=104 ГВ x 2.25) болно. Үүнд 101 ОНВ-ын (= [104 ГВ–59 ГВ] x 2.25) анхны хөнгөлөлт багтсан болно. Иймээс уг бондын ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн ханшийн зөрүү нь 532 ОНВ (=2,715 ОНВ-2,082 ОНВ-101 ОНВ) байна. Мөн тухайн жилийн хувьд хүүний авлагад хамаарах ханшийн олз нь 15 ОНВ (=59 ГВ x [2.50–2.25]) байв.

Дебит	Бонд	555 ОНВ
Дебит	Мөнгө	148 ОНВ
Дебит	Цэвэр хөрөнгө/өмч дэх бодит үнэ цэнийн өөрчлөлт	78 ОНВ
Кредит	Хүүний орлого	234 ОНВ
Кредит	Ханшийн олз	547 ОНВ

**Д.3.3 УСНББОУС 29 ба УСНББОУС 4 – Гадаад байгууллагын хөрвүүлэлтээс үүссэн ханшийн зөрүү: Цэвэр хөрөнгө/өмчид эсвэл ашиг, алдагдалд?**

Гадаад үйл ажиллагааны санхүүгийн тайлангийн хөрвүүлэлтээс үүссэн бүх ханшийн зөрүүг тухайн цэвэр хөрөнгө оруулалтыг данснаас хасах хүртэл цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө гэж УСНББОУС 4-ийн 37-р параграф ба УСНББОУС 4-ийн 57-р параграфт заасан байдаг. Үүнд: ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан санхүүгийн хөрөнгө ба борлуулах боломжтой гэж ангилсан санхүүгийн хөрөнгийн аль алиныг агуулах, бодит үнэ цэнээр бүртгэсэн санхүүгийн хэрэглүүрээс үүсэх ханшийн зөрүү хамаарна.

УСНББОУС 29-ийн 64-р параграф нь ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн гэж ангилсан санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд, харин борлуулах боломжтой хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлтийг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрөхийг шаарддаг.

Хэрэв гадаад үйл ажиллагаа нь түүний санхүүгийн тайланг уг хяналт тавигч байгууллагын санхүүгийн тайлантай нэгтгэдэг хяналтанд буй байгууллага бол тэрхүү нэгтгэсэн санхүүгийн тайланд УСНББОУС 29-ийн 64-р параграф ба УСНББОУС 4-ийн 44-р параграфыг хэрхэн мөрдөх вэ?

Гадаад үйл ажиллагааны санхүүгийн тайланд санхүүгийн хэрэглүүрийг тайлагнахдаа УСНББОУС 29-ийг, харин тухайн тайлагнагч байгууллагын санхүүгийн тайланд тусган оруулахын тулд уг гадаад үйл ажиллагааны санхүүгийн тайланг хөрвүүлэхдээ УСНББОУС 4-ийг мөрдөнө.

Үлгэрчлэн харуулвал: А байгууллага нь Х улсад оршин байдаг бөгөөд түүний бүртгэлийн валют ба толилуулгын валют нь тэрхүү Х улсын орон нутгийн валют (ХОНВ) юм. Мөн А нь Y улсад өөрийн хяналтанд буй байгууллагатай (Б байгууллага) бөгөөд түүний бүртгэлийн валют нь Y улсын орон нутгийн валют (YОНВ) байна. Б байгууллага нь худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй ерийн хэрэглүүрийн өмчлөгч ба иймээс түүнийг УСНББОУС 29-ийн дагуу бодит үнэ цэнээр бүртгэдэг.

Б байгууллагын 20X0 оны санхүүгийн тайланд тусгах уг өрийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ ба дансны үнэ нь Y улсын орон нутгийн валютаар 100 YОНВ байна. А байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд уг хөрөнгийг тухайн тайлант үеийн эцэст хамаарах спот ханшаар (2.00) Х улсын орон нутгийн валютанд хөрвүүлнэ. Иймээс нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь дансны үнэ нь 200 ХОНВ (=100 YОНВ х 2.00) болно.

20X1 оны эцэст уг өрийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ нь Y улсын орон нутгийн валютаар 110 YОНВ болж өссөн. Б байгууллага нь уг худалдаа арилжааны хөрөнгийг 110 YОНВ-аар өөрийн санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрөх бөгөөд 10 YОНВ-ын бодит үнэ цэнийн олзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Тухайн жилийн туршид уг хэрэглүүрийн бодит үнэ цэнэ нь Х улсын валютаар 200

ХОНВ-аас 300 ХОНВ (=110ҮОНВ х 3.00) болж өссөний үр дүнд спот ханш нь 2.00-оос 3.00 болж нэмэгдсэн. Иймээс А байгууллага нь уг худалдаа арилжааны хөрөнгийг 330 ХОНВ-аар өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

А байгууллага нь Б байгууллагын цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланг “тухайн ажил гүйлгээний өдрийн ханш”-аар хөрвүүлнэ (УСНББОУС 4-ийн 44(б) параграф). Бодит үнэ цэнийн олз нь тухайн жилийн туршид хуримтлагддаг учраас А байгууллага нь практик үндэслэлтэй ойролцоо тооцоолол болгон дундаж ханшийг (УСНББОУС 4-ийн 25-р параграфын дагуу  $[3.00 + 2.00] / 2 = 2.50$ ) ашигладаг. Иймээс уг худалдаа арилжааны хөрөнгийн бодит үнэ цэнэ нь 130 ХОНВ (=330 ХОНВ – 200 ХОНВ)-аар нэмэгдсэн боловч А байгууллага нь УСНББОУС 4-ийн 44(б) параграфыг даган мөрдөхийн тулд зөвхөн энэхүү 25 ХОНВ (=10 ҮОНВ х 2.5)-ын өсөлтийг өөрийн нэгтгэсэн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Үр дүн болох ханшийн зөрүүг өөрөөр хэлбэл, өрийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өсөлтийн үлдсэн дүнг (130 ХОНВ – 25 ХОНВ = 105 ХОНВ) тэрхүү гадаад үйл ажиллагаан дахь цэвэр хөрөнгө оруулалтыг данснаас хасах хүртэл УСНББОУС 4-ийн 57-р параграфын дагуу цэвэр хөрөнгө/өмчид хуримтлуулан бүртгэнэ.

#### Д.3.4 **УСНББОУС 29 ба УСНББОУС 4: УСНББОУС 29 ба УСНББОУС 4-ийн хоорондох уялдаа холбоо**

**УСНББОУС 29 нь санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг хэмжих, түүнчлэн дахин хэмжилтээс үүссэн олз ба гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх талаархи шаардлагуудыг агуулсан байдаг. УСНББОУС 4 нь гадаад валютаар илэрхийлэгдсэн зүйлсийг тайлагнах ба ханшийн зөрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх талаархи дүрмийг тусгасан байдаг. УСНББОУС 4 ба УСНББОУС 29-ийг ямар дарааллаар мөрдөх вэ?**

##### *Санхүүгийн байдлын тайлан*

Ерөнхийдөө, санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнэ, өртөг эсвэл хорогдуулсан өртгөөр хэмжилтийг УСНББОУС 29-ийн дагуу тухайн зүйлийг илэрхийлсэн гадаад валютаар эхлээд тодорхойлно. Дараа нь, хаалтын ханш эсвэл түүхэн ханшийг ашигласнаар уг гадаад валютын дүнг УСНББОУС 4 (УСНББОУС 29-ийн МЗУ116-р параграф)-ийн дагуу бүртгэлийн валютанд хөрвүүлнэ. Жишээлбэл; мөнгөн зүйлсийн санхүүгийн хөрөнгийг (өрийн хэрэглүүр гэх мэт) УСНББОУС 29-ийн дагуу хорогдуулсан өртгөөр бүртгэдэг бол уг хорогдуулсан өртгийг тухайн санхүүгийн хөрөнгийг илэрхийлсэн валютаар тооцоолно. Дараа нь, уг гадаад валютын дүнг тухайн байгууллагын санхүүгийн тайланд хаалтын ханшийг ашиглан хүлээн зөвшөөрнө (УСНББОУС 4-ийн 27-р параграф). Мөнгөн зүйлийг тухайн гадаад валютаар илэрхийлэгдсэн өртгөөр, хорогдуулсан өртгөөр эсвэл бодит үнэ цэнээр хэмждэг эсэхээс үл хамааран ингэж мөрдөнө (УСНББОУС 4-ийн 28-р параграф). Хэрэв мөнгөн зүйлийн бус санхүүгийн хөрөнгийг (өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө хөрөнгө оруулалт гэх мэт) бодит үнэ цэнээр (УСНББОУС 4-ийн 27(в) параграф) бүртгэдэг бол хаалтын ханшийг ашиглан, харин бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй (УСНББОУС 4-ийн 27(б) параграф ба УСНББОУС 29-ийн 48-р параграф) учраас УСНББОУС 29-ийн дагуу бодит үнэ цэнээр бүртгэдэггүй бол түүхэн ханшийг ашиглан гадаад валютанд хөрвүүлнэ.

Хэрэв санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг УСНББОУС 29-ийн дагуу гадаад валютын ханшийн өөрчлөлтийн эрсдлийн бодит үнэ цэнийн хейжийн хувьд хейжийн зүйл гэж сонгосон бол хэдийгээр түүнийг УСНББОУС 4 (УСНББОУС 29-ийн 99-р параграф)-ийн дагуу түүхэн ханшийг ашиглан хүлээн зөвшөөрөх байсан боловч тэрхүү хейжийн зүйлийг гажих нөхцөл болгон тухайн гадаад валютын ханшийн өөрчлөлтийн хувьд дахин хэмжинэ. Өөрөөр хэлбэл, гадаад валютын дүнг хаалтын ханш ашиглан хүлээн зөвшөөрнө. Гадаад валютаар илэрхийлэгдсэн түүхэн өртгөөр бүртгэдэг бөгөөд гадаад валютын ханшийн эрсдлийн хувьд хейж хийдэг (УСНББОУС 4-ийн 27(б) параграф) мөнгөн бус зүйлсэд энэхүү гажих нөхцлийг мөрдөнө.

### *Ашиг, алдагдал*

Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн дансны үнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөлт нь олон хүчин зүйлсээс хамаардаг. Үүнд: энэ нь ханшийн зөрүү эсвэл дансны үнийн бусад өөрчлөлт эсэх, мөнгөн зүйлсээс (жишээлбэл; ихэнх өрийн хэрэглүүр) эсвэл мөнгөн бус зүйлсээс (жишээлбэл; ихэнх өмчийн хөрөнгө оруулалт) үүссэн эсэх, холбогдох хөрөнгө буюу өр төлбөрийг гадаад валютын ханшийн өөрчлөлтийн эрсдлийн хувьд мөнгөн гүйлгээний хейж гэж сонгосон эсэх, энэ нь гадаад үйл ажиллагааны санхүүгийн тайланг хөрвүүлсэнээс үүссэн эсэх гэх мэт. Гадаад үйл ажиллагааны эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн дансны үнийн өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөх асуудлыг өөр асуултанд (Асуулт Д.3.3-ыг үзнэ үү) авч үзнэ.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн, өндөр магадлалтай урьдчилан таамагласан ажил гүйлгээний мөнгөн гүйлгээний хейж гэж уг мөнгөн зүйлийг сонгосон, ингэснээр УСНББОУС 29 (УСНББОУС 29-ийн 106-р параграф)-д заасан мөнгөн гүйлгээний хейжийн олз, гарзын хүлээн зөвшөөрөлтийн шаардлагуудыг мөрдөхөөс бусад тохиолдолд, тухайн тайлант үед анх хүлээн зөвшөөрсөн эсвэл өмнөх санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн ханшаас өөр ханшаар мөнгөн зүйлийг хүлээн зөвшөөрснөөр үүссэн аливаа ханшийн зөрүүг УСНББОУС 4 (УСНББОУС 29-ийн МЗУ116-р параграф, УСНББОУС 4-ийн 32-р параграф ба УСНББОУС 4-ийн 37-р параграф)-ийн дагуу ашиг, алдагдалд эсвэл цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө. Гадаад валютын хөдөлгөөнтэй холбоотой дансны үнийн бүх өөрчлөлтүүдийг нэг мөр тууштай тайлагнах хэрэгтэй учраас өмнө хүлээн зөвшөөрсөн дүнгээс өөр дүн бүхий гадаад валютаар мөнгөн зүйлийг хүлээн зөвшөөрснөөр үүсэх зөрүүг дээрхтэй адил байдлаар тайлагнана. Мөнгөн зүйлийг санхүүгийн байдлын тайланд хэмжихтэй холбоотой бусад бүх өөрчлөлтүүдийг УСНББОУС 29-ийн дагуу ашиг, алдагдалд эсвэл цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө. Жишээлбэл; байгууллага нь борлуулах боломжтой мөнгөн зүйлийн санхүүгийн хөрөнгийн олз, гарзыг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрдөг (УСНББОУС 29-ийн 64(б) параграф) боловч тухайн байгууллага нь гадаад валютын ханшийн өөрчлөлтөнд хамаарах дансны үнийн өөрчлөлтийг ямар ч байсан ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө (УСНББОУС 4-ийн 27(а) параграф).

Мөнгөн бус зүйлийн дансны үнийн аливаа өөрчлөлтийг УСНББОУС 29-ийн (УСНББОУС 29-ийн МЗУ116-р параграф) дагуу ашиг, алдагдалд эсвэл цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө. Жишээлбэл; борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгийн хувьд, дансны үнийн нийт өөрчлөлтийг, үүн дотроо гадаад валютын



ханшийн өөрчлөлтийн үр нөлөөг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө. Гадаад валютаар илэрхийлсэн, хүлээн зөвшөөрөөгүй арилжааны баталгаа эсвэл өндөр магадлалтай урьдчилан таамагласан ажил гүйлгээний мөнгөн гүйлгээний хейж гэж тухайн мөнгөн бус зүйлийг сонгосон бол УСНББОУС 29 (УСНББОУС 29-ийн 106-р параграф)-д заасан мөнгөн гүйлгээний хейжийн олз, гарзыг хүлээн зөвшөөрөлтийн шаардлагуудыг мөрдөнө.

Жишээлбэл; борлуулах боломжтой гэж ангилсан, гадаад валютаар илэрхийлсэн бондын хорогдуулсан өртөг нь гадаад валютаар нэмэгдсэн (үр дүн болох олзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн) боловч түүний бодит үнэ цэнэ нь бүртгэлийн валютаар буурснаар (үр дүн болох гарзыг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн) дансны үнийн өөрчлөлтийн зарим хэсгийг цэвэр хөрөнгө/өмчид, харин зарим хэсгийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн тохиолдолд байгууллага нь ашиг, алдагдалд эсвэл цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрөх олз, гарзыг тодорхойлох зорилгоор энэхүү хоёр бүрэлдэхүүн хэсгүүдийг харилцан суутгаж, цэвэр дүнг гаргаж болохгүй.

Д.4 *Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт ба үл цуглуулагдах байдал*

#### Д.4.1 *Үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо*

**Санхүүгийн хөрөнгөнд үнэ цэнийн бууралтын гарз үүсэх нилээд магадлалтай гэж дүгнэхийн тулд байгууллага нь түүний шалтгаан болох ялган тодорхойлж болох нэг өнгөрсөн үйл явдлыг тодорхойлох боломжтой байхыг УСНББОУС 29-өөр шаарддаг уу?**

Үгүй. УСНББОУС 29-ийн 68-р параграфт “Үнэ цэнийн бууралтанд хүргэсэн ганц, тусдаа үйл явдлыг тодорхойлох боломжгүй байж болох юм. Харин хэд хэдэн үйл явдлуудын нэгдсэн үр нөлөө нь үнэ цэнийн бууралтын шалтгаан байж болно” гэж заасан. Мөн УСНББОУС 29-ийн 69-р параграфт “байгууллагын зээлийн үнэлэмжийн бууралт нь бусад боломжит мэдээллийн хамт авч үзэх үед үнэ цэнийн бууралтын нотолгоо байж болох боловч энэ нь дангаараа, үнэ цэнийн бууралтын нотолгоо болохгүй” гэж заасан. Үнэ цэнийн бууралтын гарз үүссэн гэсэн бодит нотолгоо байгаа эсэхийг тодорхойлохдоо тухайн байгууллагын харгалзан үзэх бусад хүчин зүйлсэд зээлдэгч буюу гаргагчийн хөрвөх чадвар, төлбөрийн чадвар, бизнесийн болон санхүүгийн эрсдэл, ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгөнд ийм тохиолдол үүссэн түвшин ба хандлага, үндэсний болон орон нутгийн эдийн засгийн хандлага ба нөхцөл байдал, барьцаа ба баталгааны бодит үнэ цэнэ зэргийн талаархи мэдээлэл хамаарна. Тус тусад нь эсвэл хамтад нь авч үзэхэд, эдгээр болон бусад хүчин зүйлс нь санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн хөрөнгүүдийн бүлэгт үнэ цэнийн бууралтын гарз үүссэн талаархи хангалттай ба бодитой нотолгоогоор хангаж болох юм.

#### Д.4.2 *Үнэ цэнийн бууралт: Ирээдүйн гарз*

**Зээл олгох үед ирээдүйн гарзад зориулсан хасагдуулга байгуулснаар үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөхийг УСНББОУС 29-өөр зөвшөөрдөг үү? Жишээлбэл; А байгууллага нь Б үйлчлүүлэгчид 1,000ТН-ийн зээл олгосон бөгөөд өөрийн түүхэн туршлагадаа үндэслэн, А байгууллага нь**

**олгосон зээлийн үндсэн дүнгийн 1 хувийг цуглуулж чадахгүй гэж үзэж байгаа бол тэрээр 10 ТН-ийн гарзыг нэн даруй хүлээн зөвшөөрч болох уу?**

Үгүй. УСНББОУС 29-ийн 45-р параграф нь санхүүгийн хөрөнгийг эхлээд бодит үнэ цэнээр хэмжихийг шаарддаг. Зээлийн хөрөнгийн хувьд, түүний бодит үнэ цэнэ нь (зээлдүүлсэн дүнгийн зарим хэсэг нь тогтоосон буюу дам илэрхийлсэн бусад эрх болон давуу эрхийн нөхөн төлбөр байхаас бусад тохиолдолд) аливаа шимтгэл ба зардлын хувьд тохируулга хийсэн, уг зээлдүүлсэн мөнгөн дүн байдаг. Мөн түүнчлэн, анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа гарч тохиолдсон өнгөрсөн үйл явдлын үр дүнд үнэ цэнийн бууралт үүссэн гэсэн бодит нотолгоо байгаа зөвхөн тийм тохиолдолд үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөхийг УСНББОУС 29-ийн 68-р параграфтаар шаардсан байдаг. Иймээс үнэ цэнийн бууралтын гарзыг нэн даруй хүлээн зөвшөөрснөөр зээлийн хөрөнгийн дансны үнийг анх хүлээн зөвшөөрөх үед бууруулах нь УСНББОУС 29-ийн 45-р параграф ба УСНББОУС 29-ийн 68-р параграфтай нийцэхгүй юм.

**Д.4.3 Үнэ цэнийн бууралтын үнэлгээ: Үндсэн дүн ба хүү**

**Б үйлчлүүлэгчийн санхүүгийн хүндрэлтэй байдлын улмаас А байгууллага нь уг зээлийн дагуу төлөх бүх үндсэн дүн ба хүүг Б байгууллага цаг хугацаанд нь төлж чадахгүй гэдэгт санаа зовж байна. А байгууллага нь тухайн зээлийн нөхцлийг шинэчлэхээр тохиролцсон. А байгууллага нь уг шинэчилсэн нөхцлийн дагуу Б харилцагч өөрийн үүргийг биелүүлэх боломжтой гэж үзэж байна. Хэрэв шинэчилсэн нөхцөл нь дараах аль нэг тохиолдолд тусгасантай ижил бол А байгууллага нь үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөх үү?**

- (а) **Б харилцагч нь анхны төлөх ёстой өдрөөс хойшхи таван жилийн хугацаанд уг анхны зээлийн үндсэн дүнг бүрэн төлөх боловч анхны нөхцлийн дагуу төлөх ёстой хүүг төлөхгүй.**
- (б) **Б харилцагч нь анхны төлөх ёстой хугацаанд уг анхны зээлийн үндсэн дүнг бүрэн төлөх боловч анхны нөхцлийн дагуу төлөх ёстой хүүг төлөхгүй.**
- (в) **Б харилцагч нь анхны зээлд тусгагдсан хүүний түвшнээс арай бага хүүтэй байх зөвхөн тийм тохиолдолд анхны төлөх ёстой хугацаанд уг анхны зээлийн үндсэн дүнг түүний хүүний хамтаар бүрэн төлнө.**
- (г) **Б харилцагч нь анхны төлөх ёстой өдрөөс хойшхи таван жилийн хугацаанд уг анхны зээлийн үндсэн дүнг бүрэн төлөх ба тухайн зээлийн анхны хуваарийн дагуу хуримтлагдах бүх хүүг төлөх боловч тэрхүү сунгасан хугацаанд хамаарах хүүг төлөхгүй.**
- (д) **Б харилцагч нь анхны төлөх ёстой өдрөөс хойшхи таван жилийн хугацаанд уг анхны зээлийн үндсэн дүнг, түүнчлэн тухайн зээлийн анхны болон сунгасан хугацааны аль алинд хамаарах бүх хүүг төлнө.**

Хэрэв үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа бол үнэ цэнийн бууралтын гарз үүссэн гэж УСНББОУС 29-ийн 68-р параграфт заасан байдаг. Хорогдуулсан өртгөөр хэмжсэн зээлийн үнэ цэнийн бууралтын гарзын дүн нь тухайн зээлийн анхны үр ашигт хүүний түвшнээр дискаунтчилсан ирээдүйн үндсэн дүн болон хүүний төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнэ ба тэрхүү зээлийн дансны үнэ хоорондох зөрүү юм. Дээрх (а)-(г) тохиолдолд тухайн зээлийн анхны үр ашигт хүүний түвшнээр дискаунтчилсан ирээдүйн үндсэн дүн болон хүүний төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнэ нь тэрхүү зээлийн дансны үнээс бага байна. Иймээс эдгээр тохиолдолд үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрнө.

Харин (д) тохиолдолд, төлбөрийн хугацаа өөрчлөгдсөн боловч зээлдүүлэгч нь хүүний хүүг авах бөгөөд тухайн зээлийн анхны үр ашигт хүүний түвшнээр дискаунтчилсан ирээдүйн үндсэн дүн болон хүүний төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнэ нь тэрхүү зээлийн дансны үнэтэй тэнцүү байна. Иймээс үнэ цэнийн бууралтын гарз үүсэхгүй. Гэвч Б харилцагчийн санхүүгийн хүндрэлтэй байдлыг харгалзан үзвэл ингэж төлөх магадлал багатай юм.

#### Д.4.4 Үнэ цэнийн бууралтын үнэлгээ: Бодит үнэ цэнийн хейж

**Тогтмол хүүтэй зээлийг хүүний түвшний эрсдлээс хамгаалахын тулд хувьсах хүү-хүлээн авах ба тогтмол хүү-төлөх хүүний түвшний свопоор хейж хийсэн. Уг хейжийн харилцаа нь бодит үнэ цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангах бөгөөд бодит үнэ цэнийн хейж гэж тайлагнадаг. Иймээс тухайн зээлийн дансны үнэ нь хүүний түвшний өөрчлөлт хөдөлгөөнд хамаарах бодит үнэ цэнийн өөрчлөлтийн тохируулгыг тусган агуулсан байдаг. Зээлийн үнэ цэнийн бууралтын үнэлгээнд уг хүүний түвшний эрсдлийн бодит үнэ цэнийн тохируулгыг харгалзан үзэх үү?**

Тийм. Хүүний түвшний өөрчлөлт хөдөлгөөнд хамаарах бодит үнэ цэнийн аливаа өөрчлөлтийн хувьд зээлийн дансны үнийг тохируулмагц тэрхүү хейжийн өмнөх уг зээлийн анхны үр ашигт хүүний түвшин хамааралгүй болно. Иймээс тухайн хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг харгалзан тусгахын тулд уг зээлийн анхны үр ашигт хүүний түвшин болон хорогдуулсан өртөгт тохируулга хийнэ. Тохируулсан үр ашигт хүүний түвшинг тухайн зээлийн тохируулсан дансны үнийг ашиглан тооцоолно.

Хейж хийж буй эрсдэлд хамаарах бодит үнэ цэнийн өөрчлөлтийн хувьд хийгдэх тохируулгын дараах дансны үнэ ба уг тохируулсан үр ашигт хүүний түвшнээр дискаунтчилсан тухайн зээлийн ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээ хоорондох зөрүү байдлаар тэрхүү хейж хийсэн зээлийн үнэ цэнийн бууралтын гарзыг тооцоолно. Зээлийг хүүний түвшний эрсдлийн багц хейжид тусган оруулдаг тохиолдолд байгууллага нь уг хейж хийсэн багцын бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тэрхүү үнэ цэнийн бууралтыг нь үнэлж буй зээлд (ижил төсөөтэй зээлүүдийн бүлэгт) системтэй ба ул үндэслэлтэй сууриар хуваарилна.

#### Д.4.5 Үнэ цэнийн бууралт: Хасагдуулгын матриц

**Хэвийн бус гэж ангилсан зээлийн хоног тутамд хасагдуулгыг тогтмол хувь хэмжээгээр (90 хүртэл хоногт тэг (0) хувиар, 90-180 хоногт 20 хувиар, 181-365**

**хоногт 50 хувиар, 365 хоногоос дээш бол 100 хувиар) байгуулахаар заасан хасагдуулгын матрицад үндэслэн байгууллага нь зээл ба авлагын баталгаагүй хэсгийн хувьд үнэ цэнийн бууралтыг тооцоолдог. Ийм тооцооллын үр дүн нь зээл ба авлагын үнэ цэнийн бууралтын гарзыг УСНББОУС 29-ийн 72-р параграфын дагуу тооцоолох зорилгын хувьд тохиромжтой гэж үзэх үү?**

Тэгж үзэх албагүй. УСНББОУС 29-ийн 72-р параграф нь санхүүгийн хэрэглүүрийн анхны үр ашигт хүүний түвшнээр дискаунтчилсан ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ ба тухайн хөрөнгийн дансны үнэ хоорондох зөрүү байдлаар үнэ цэнийн бууралт буюу найдваргүй авлагын гарзыг тооцоолохыг шаарддаг.

#### **Д.4.6 Үнэ цэнийн бууралт: Хэтэрсэн гарз**

**Байгууллага нь бие даасан байдлаар тодорхойлсон санхүүгийн хөрөнгүүд буюу ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгүүдийн тодорхойлсон бүлгүүдийн үнэ цэнийн бууралтын талаархи бодит нотолгоонд үндэслэн тодорхойлогдох уг үнэ цэнийн бууралтын гарзын хэтрэлтийн хувьд үнэ цэнийн бууралт буюу найдваргүй авлагын гарз хүлээн зөвшөөрөхийг УСНББОУС 29-өөр зөвшөөрдөг үү?**

Үгүй. Тухайн хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралтын оршин байдлын талаархи бодит нотолгоонд (УСНББОУС 29-ийн 68-р параграф) үндэслэн байгууллага нь уг бие даасан байдлаар тодорхойлсон санхүүгийн хөрөнгүүд буюу ижил төсөөтэй зээлийн эрсдлийн шинж чанар бүхий санхүүгийн хөрөнгүүдийн тодорхойлсон бүлгүүдэд (УСНББОУС 29-ийн 73-р параграф) хамааруулж болох гарзаас өөр бусад, үнэ цэнийн бууралт буюу найдваргүй авлагын гарз хүлээн зөвшөөрөхийг УСНББОУС 29-өөр зөвшөөрдөггүй. Үнэ цэнийн бууралтын талаархи бодит нотолгоогоор дэмжигдээгүй хасагдуулга гэх мэт санхүүгийн хөрөнгийн болзошгүй нэмэлт үнэ цэнийн бууралтын хувьд тухайн байгууллагын байгуулахыг хүсэж болох дүнг УСНББОУС 29-ийн дагуу үнэ цэнийн бууралт буюу найдваргүй авлагын гарз гэж хүлээн зөвшөөрөхгүй. Гэвч байгууллага нь мэдэгдэхүйц дүнтэй эсэхээс үл хамааран бие даасан байдлаар үнэлсэн санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралт үүссэн талаархи бодит нотолгоо байхгүй гэж тодорхойлсон бол тэрхүү хөрөнгийг ижил төсөөтэй зээлийн эрсдлийн шинж чанар бүхий санхүүгийн хөрөнгүүдийн бүлэгт тусган оруулна.

#### **Д.4.7 Үнэ цэнийн бууралтыг багцаар хүлээн зөвшөөрөх**

**Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралт хүлээн зөвшөөрөхийг УСНББОУС 29-ийн 72-р параграфтаар шаарддаг. Ижил төсөөтэй санхүүгийн хөрөнгүүдийн бүлгийн хувьд үнэ цэнийн бууралтыг бие даасан байдлаар эсвэл багцын сууриар хэмжиж, хүлээн зөвшөөрч болно гэж УСНББОУС 29-ийн 73-р параграфт заасан байдаг. Хэрэв тухайн бүлэг дэх нэг хөрөнгийн үнэ цэнэ буурсан боловч тэрхүү бүлэг дэх өөр нэг хөрөнгийн бодит үнэ цэнэ нь түүний хорогдуулсан өртгөөс илүү байвал эхэнд дурдсан хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрөхгүй байхыг УСНББОУС 29-өөр зөвшөөрдөг үү?**

Үгүй. Хэрэв байгууллага нь хорогдуулсан өртгөөр бүртгэсэн бие даасан санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан гэдгийг мэдэж байгаа бол тэрхүү хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрөхийг УСНББОУС 29-ийн 72-р параграфтаар шаарддаг. Энэ параграфт “уг санхүүгийн хөрөнгийн анхны үр ашигт хүүний түвшнээр дискаунтчилсан ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээний (хараахан гарч тохиолдоогүй байгаа ирээдүйн зээлийн алдагдлыг оруулахгүй) өнөөгийн үнэ цэнэ ба тэрхүү хөрөнгийн дансны үнэ хоорондох зөрүүгээр гарзын дүнг хэмжинэ” гэж заасан (нэмж ташуу болгон онцлон харуулав). Ижил төсөөтэй хөрөнгүүдийн бүлэгт үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг байгаа бөгөөд тухайн бүлэг дэх бие даасан хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралтыг тодорхойлж чадахгүй тохиолдолд УСНББОУС 29-ийн 73-р параграфын дагуу багцын сууриар хийгдэх үнэ цэнийн бууралтын хэмжилтийг бага дүн бүхий үлдэгдэлтэй зүйлсийн бүлэгт, түүнчлэн бие даасан байдлаар үнэлсэн ба үнэ цэнэ буурсан гэж тогтоогоогүй санхүүгийн хөрөнгүүдэд мөрдөж болох юм.

#### Д.4.8 Үнэ цэнийн бууралт: Барьцааны хүлээн зөвшөөрөлт

**Үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгийг бусад Стандартад заасан хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангахгүй тийм барьцаагаар хамгаалсан бол тэрхүү барьцааг уг үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгөөс тусад нь хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх үү?**

Үгүй. Үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгийн хэмжилт нь тухайн барьцааны бодит үнэ цэнийг тусгадаг. Барьцаа нь бусад Стандартад заасан хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангахаас бусад тохиолдолд уг барьцааг тухайн үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгөөс тусад нь хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхгүй.

#### Д.4.9 Борлуулах боломжтой мөнгөн зүйлийн бус санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

**Олз, гарзыг нь цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрснөөр бодит үнэ цэнээр хэмждэг өмчийн хэрэглүүр гэх мэт мөнгөн зүйлийн бус санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан бол цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн, хуримтлагдсан цэвэр гарзыг, үүн дотроо гадаад валютын өөрчлөлтөнд хамаарах түүний аливаа хэсгийг цэвэр хөрөнгө/өмчөөс дахин ангилах залруулга байдлаар ашиг, алдагдалд дахин ангилах үү?**

Тийм. Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн бууралтыг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрдөг бөгөөд тухайн хөрөнгийн үнэ цэнэ буурсан гэсэн бодит нотолгоо байгаа тохиолдолд хэдийгээр уг хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөөгүй ч гэсэн цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн, хуримтлагдсан цэвэр гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө гэж УСНББОУС 29-ийн 76-р параграфт заасан байдаг. Тухайн хөрөнгийн гадаад валютын өөрчлөлтөнд хамаарах бөгөөд цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрч байсан, хуримтлагдсан цэвэр гарзын аливаа хэсгийг мөн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Дараагийн тайлант үеийн аливаа гарзыг, үүн дотроо гадаад валютын өөрчлөлтөнд хамаарах түүний аливаа хэсгийг тухайн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх хүртэл мөн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

**Д.4.10 Үнэ цэнийн бууралт: Цэвэр хөрөнгө/өмчид тусгасан борлуулах боломжтой нөөц нь сөрөг байж болох эсэх**

**УСНББОУС 29 нь борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарзыг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрөхийг шаарддаг. Хэрэв ийм хөрөнгүүдийн нэгтгэн нийлүүлсэн бодит үнэ цэнэ нь тэдгээрийн дансны үнээс бага бол цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрч байсан уг нэгдсэн цэвэр гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх үү?**

Зайлшгүй шаардлагатай биш. Холбогдох шалгуур нь тухайн нэгтгэн нийлүүлсэн бодит үнэ цэнэ түүний дансны үнээс бага болох эсэх биш, харин уг санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн хөрөнгүүдийн бүлгийн үнэ цэнэ буурсан гэсэн бодитой нотолгоотой байх явдал юм. УСНББОУС 29-ийн 68-70-р параграфт заасанчлан, байгууллага нь санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн хөрөнгүүдийн бүлгийн үнэ цэнэ буурсан гэсэн ямар нэг бодит нотолгоо байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст үнэлж үзнэ. Байгууллагын зээлийн үнэлэмжийн бууралт нь бусад боломжит мэдээллийн хамт авч үзэх үед үнэ цэнийн бууралтын нотолгоо байж болох боловч энэ нь дангаараа, үнэ цэнийн бууралтын нотолгоо болохгүй гэж УСНББОУС 29-ийн 69-р параграфт заасан. Түүнчлэн, санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ түүний өртөг буюу хорогдуулсан өртгөөс бага болох бууралт нь үнэ цэнийн бууралтын нотолгоо байх албагүй юм (жишээлбэл; эрсдэлгүй, суурь хүүний түвшний өсөлтийн үр дүнд өрийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ буурах).

**Хэсэг E: Хейж**

**E.1 Хейжийн хэрэглүүр**

**E.1.1 Гадаад валютаар илэрхийлэгдсэн бондын бодит үнэ цэнийн эрсдлийн хейж**

**Бүртгэлийн валют нь японы иен байх Жей байгууллага нь 5 сая ам долларын дүнтэй, таван жилийн хугацаатай, тогтмол хүүтэй өрийн хэрэглүүрийг гаргасан. Мөн уг байгууллага нь борлуулах боломжтой гэж ангилсан 5 сая ам долларын дүнтэй, таван жилийн хугацаатай, тогтмол хүүтэй бондыг эзэмшдэг. Жей байгууллага нь өөрийн ам долларын бондын нийт бодит үнэ цэнийн эрсдэлд хамаарах бодит үнэ цэнийн хейжийн хувьд хейжийн хэрэглүүр болгон уг ам долларын өрийн хэрэглүүрийг сонгож болох уу?**

Үгүй. Үүсмэл бус хэрэглүүрийг зөвхөн гадаад валютын эрсдлийн хейжийн хувьд хейжийн хэрэглүүр болгон ашиглахыг УСНББОУС 29-ийн 81-р параграфтаар зөвшөөрсөн байдаг. Харин Жей байгууллагын бонд нь гадаад валют, хүүний түвшний өөрчлөлт, зээлийн эрсдлийн хувьд бодит үнэ цэнийн эрсдэлд өртөхөөр байна.

**Нөгөө талаас, уг ам долларын өрийн хэрэглүүрийг тухайн бондын гадаад валютын бүрэлдэхүүн хэсгийн хувьд бодит үнэ цэнийн хейж эсвэл мөнгөн гүйлгээний хейж гэж сонгож болох уу?**

Тийм. Гэвч хейжийн хэрэглүүрийн болон хейжийн зүйлийн аль алины хорогдуулсан өртгийг хаалтын ханшаар дахин хэмждэг учраас хейжийн нягтлан бодох бүртгэл шаардлагагүй юм. Жей байгууллага нь уг харилцааг мөнгөн гүйлгээний хейж эсвэл бодит үнэ цэнийн хейж гэж сонгосон эсэхээс үл хамааран ашиг, алдагдалд үзүүлэх үр нөлөө нь ижил байна. УСНББОУС 4-өөр шаардсанчлан, хейжийн зүйлийн спот ханшийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөлттэй уялдуулахын тулд мөнгөн гүйлгээний хейж гэж сонгосон, үүсмэл бус хейжийн хэрэглүүрийн аливаа олз буюу гарзыг ашиг, алдагдалд нэн даруй хүлээн зөвшөөрнө.

#### **Е.1.2 Үүсмэл бус санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн хейж**

**Жей байгууллагын бүртгэлийн валют нь японы иен юм. Уг байгууллага нь хүүний төлбөрийг хагас жил тутам, үндсэн дүнг дуусгавар болох үед төлөх, 5 сая ам долларын дүнтэй, тогтмол хүүтэй, хоёр жилийн хугацаатай өрийн хэрэглүүрийг гаргасан. Мөн тус байгууллага нь хоёр жилийн хугацаатай, 5 сая ам.долларын тогтмол үнийн борлуулалтын баталгааг гаргасан бөгөөд энэ нь 4-р параграфт заасан, хэвийн борлуулалтанд хамаарах чөлөөлөгдөх нөхцлийг хангаж байгаа учраас үүнийг үүсмэл хэрэглүүр гэж тайлагнаагүй. Жей байгууллага нь өөрийн тогтмол үнийн борлуулалтын баталгааны нийт бодит үнэ цэнийн эрсдэлд хамаарах бодит үнэ цэнийн хейжийн хувьд хейжийн хэрэглүүр болгон уг ам долларын өрийн хэрэглүүрийг сонгож болох уу, энэ нь хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангах уу?**

Үгүй. Үүсмэл бус хөрөнгө буюу өр төлбөрийг зөвхөн гадаад валютын эрсдлийн хейжийн хувьд хейжийн хэрэглүүр болгон ашиглахыг УСНББОУС 29-ийн 81-р параграфтаар зөвшөөрсөн байдаг.

**Нөгөө талаас, Жей байгууллага нь уг ам долларын өрийн хэрэглүүрийг тухайн тогтмол үнийн борлуулалтын баталгааны дагуух ирээдүйн ам долларын мөнгөн орлоготой холбоотой гадаад валютын эрсдлийн хувьд мөнгөн гүйлгээний хейж гэж сонгож болох уу?**

Тийм. Арилжааны баталгааны гадаад валютын ханшийн өөрчлөлтийн мөнгөн гүйлгээний хейж эсвэл бодит үнэ цэнийн хейжид (УСНББОУС 29-ийн 97-р параграф) үүсмэл бус хөрөнгө буюу өр төлбөрийг хейжийн хэрэглүүр гэж сонгохыг УСНББОУС 29-өөр зөвшөөрдөг. Ирээдүйн борлуулалтаас өмнөх тайлант үеийн туршид цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрч байсан үүсмэл бус хейжийн хэрэглүүрийн аливаа олз, гарзыг тухайн борлуулалт хийгдсэн тайлант үед ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө (УСНББОУС 29-ийн 106-р параграф).

**Нөгөө талаас, Жей байгууллага нь уг борлуулалтын баталгааг хейжийн зүйл биш, харин хейжийн хэрэглүүр гэж сонгож болох уу?**

Үгүй. Зөвхөн үүсмэл хэрэглүүр эсвэл үүсмэл бус санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг гадаад валютын эрсдлийн хейжид хейжийн хэрэглүүр гэж сонгож болно.

Арилжааны баталгааг хейжийн хэрэглүүр гэж сонгож болохгүй. Гэвч уг борлуулалтын баталгааны гадаад валютын бүрэлдэхүүн хэсгийг УСНББОУС 29-ийн 12-р параграф ба УСНББОУС 29-ийн МЗУ46-р параграфын дагуу дагалдах үүсмэл хэрэглүүр байдлаар салган тусгаарлах шаардлагатай бол уг өрийн хэрэглүүрийн дуусгавар болгох дүнгийн бодит үнэ цэнийн гадаад валютын эрсдэлд хамаарах өөрчлөлтийн хейжийн хувьд энэхүү борлуулалтын баталгааг хейжийн хэрэглүүр гэж сонгож болно.

**Е.1.3 Хейжийн нягтлан бодох бүртгэл: Гаргасан опционыг нэгдсэн хейжийн хэрэглүүрт ашиглах**

**Асуудал (а) - Гаргасан опционы бүрэлдэхүүн хэсэг ба худалдан авсан опционы бүрэлдэхүүн хэсгийг нэгтгэн нийлүүлдэг хүүний түвшний баталгаа буюу бусад үүсмэл хэрэглүүрийг хейжийн хэрэглүүр байдлаар ашиглахыг УСНББОУС 29-ийн МЗУ127-р параграфтаар хориглодог уу?**

Нөхцөл байдлаас хамаарна. Гаргасан опцион нь худалдан авсан опционы нөхөлт гэж сонгогдсоноос бусад тохиолдолд уг гаргасан опционыг хейжийн хэрэглүүр гэж ашиглахыг УСНББОУС 29-ийн МЗУ127-р параграфтаар хориглодог учраас гаргасан опционыг агуулсан хүүний түвшний баталгаа буюу бусад үүсмэл хэрэглүүр нь гаргасан цэвэр опцион бол түүнийг хейжийн хэрэглүүр гэж сонгож болохгүй. Харин нэгдсэн эцсийн дүнгээрээ худалдан авсан цэвэр опцион эсвэл тэг (0) өртөгтэй хүүний түвшний баталгаа бол гаргасан опционыг агуулсан хүүний түвшний баталгаа буюу бусад үүсмэл хэрэглүүрийг хейжийн хэрэглүүр гэж сонгож болно.

**Асуудал (б) – Гаргасан опционы бүрэлдэхүүн хэсэг ба худалдан авсан опционы бүрэлдэхүүн хэсгийг нэгтгэн нийлүүлсэн хүүний түвшний баталгаа буюу бусад үүсмэл хэрэглүүр нь гаргасан цэвэр опцион биш гэдгийг ямар хүчин зүйлс илтгэн харуулах вэ?**

Гаргасан опционыг агуулдаг хүүний түвшний баталгаа буюу бусад үүсмэл хэрэглүүр нь гаргасан цэвэр опцион биш гэдгийг дараах хүчин зүйлс хамтдаа илэрхийлнэ.

- (а) Опционуудын нэгтгэл үүссэн үед эсвэл тийм нэгтгэлийн хугацаанд цэвэр урамшуулал хүлээн аваагүй. Гаргасан опционы ялгагдах онцлог шинж нь хүлээсэн эрсдлийн хувьд тухайн гаргагчид нөхөн төлбөр олгох урамшууллын хүлээн авалт юм.
- (б) Гаргасан опционы бүрэлдэхүүн хэсгийн болон худалдан авсан опционы бүрэлдэхүүн хэсгийн гол чухал нөхцөл, болзол нь хэрэгжүүлэх үнээс бусад зүйлсийн (үүн дотроо, суурь хувьсагч буюу хувьсагчууд, илэрхийлсэн валют, дуусгавар болох хугацаа) хувьд ижил байдаг. Түүнчлэн, гаргасан опционы бүрэлдэхүүн хэсгийн нэрлэсэн дүн нь худалдан авсан опционы бүрэлдэхүүн хэсгийн нэрлэсэн дүнгээс илүүгүй байдаг.



#### Е.1.4 Дотоод хейж

**Зарим байгууллагууд нь эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх өөр өөр байгууллагуудын хооронд, эсвэл нэгж хуулийн этгээдийн доторх хэлтсүүдийн хооронд эрсдлийг шилжүүлэхийн тулд дотоодын үүсмэл гэрээг (дотоод хейж) ашигладаг. Ийм тохиолдолд хейжийн нягтлан бодох бүртгэлийг УСНББОУС 29-ийн 82-р параграфтаар хориглодог уу?**

Тийм. Хэрэв үүсмэл гэрээ нь тухайн тайлагнаж буй байгууллагын хувьд дотоод гэрээ бол уг байгууллага нь өөрийн эрсдлийг хэрхэн удирдан зохицуулахыг УСНББОУС 29-д тусгайлан заагаагүй. Гэвч дотоод хейжийн ажил гүйлгээ нь хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангахгүй гэдийг уг Стандартад заасан. Үүнийг дараах хоёр тохиолдлын аль алинд мөрдөнө: (а) эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх хейжийн ажил гүйлгээний хувьд нэгтгэсэн санхүүгийн тайланд, (б) нэг хуулийн этгээдийн доторх хэлтсүүдийн хоорондох хейжийн ажил гүйлгээний хувьд уг байгууллагын бие даасан буюу тусдаа санхүүгийн тайланд. УСНББОУС 35-ын 40-р параграфт заасан, нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх зарчмууд нь “эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх байгууллагуудын хоорондох ажил гүйлгээтэй холбоотой байгууллага хоорондын хөрөнгө ба өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмч, орлого ба зардал, мөнгөн гүйлгээг бүрэн устган цэвэрлэх”-ийг тухайн хяналт тавигч байгууллагаас шаарддаг.

Нөгөө талаас, хэрэв ажил гүйлгээ нь тухайн эдийн засгийн нэгдмэл байгууллагын зүгээс авч үзэхэд гаднын ажил гүйлгээ бол уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх хейжийн ажил гүйлгээг тэрхүү бие даасан байгууллагын бие даасан буюу тусдаа санхүүгийн тайланд хейж гэж сонгож болох юм. Мөн түүнчлэн, дотоод гэрээ нь гаднын талтай харилцан суутгагдаж, цэвэр дүнг гаргадаг бол тэрхүү гаднын гэрээг хейжийн хэрэглүүр гэж үзэж болох бөгөөд тухайн хейжийн харилцаа нь хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангаж болох юм.

Дотоод хейжийн ажил гүйлгээнд УСНББОУС 29-ийн мөрдөлтийг доор нэгтгэн харуулав:

- Байгууллага нь эрсдлийн удирдлагын зорилгоор дотоод үүсмэл гэрээ ашиглахыг УСНББОУС 29-өөр хориглодоггүй, түүнчлэн тухайн байгууллагын хэмжээнд эсвэл уг тусдаа хуулийн этгээд буюу хэлтсээс арай дээд тодорхой түвшинд удирдан зохицуулахын тулд төрийн сангийн түвшинд болон бусад зарим төвлөрсөн байршилд дотоод үүсмэл хэрэглүүрийг хуримтлуулахыг энэ Стандартаар хориглодоггүй.
- Эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх хоёр тусдаа байгууллагын хооронд байгуулсан дотоод үүсмэл гэрээ нь уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын хувьд гаднын болох талтай байгуулсан үүсмэл гэрээгээр харилцан нөхөгдөхгүй боловч тэдгээр байгууллагуудын бие даасан буюу тусдаа санхүүгийн тайланд хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангана.
- Нэг хуулийн этгээдийн доторх хоёр тусдаа хэлтсийн хооронд байгуулсан дотоод үүсмэл гэрээ нь уг хуулийн этгээдийн хувьд гаднын болох талтай

байгуулсан үүсмэл гэрээгээр харилцан нөхөгдөх зөвхөн тийм тохиолдолд тухайн хуулийн этгээдийн бие даасан буюу тусдаа санхүүгийн тайланд хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангана.

- Нэг хуулийн этгээдийн доторх тусдаа хэлтсүүдийн хооронд болон нэг эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрэн дэх хоёр тусдаа байгууллагын хооронд байгуулсан дотоод үүсмэл гэрээ нь уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын хувьд гаднын болох талтай байгуулсан үүсмэл гэрээгээр харилцан нөхөгдөх зөвхөн тийм тохиолдолд нэгтгэсэн санхүүгийн тайланд хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангана.
- Дотоод үүсмэл гэрээ нь гаднын талуудтай байгуулсан үүсмэл гэрээгээр харилцан нөхөгдөхгүй бол дотоод гэрээг ашигласнаар тэдгээр бие даасан байгууллагууд болон хэлтсүүдийн тайлагнасан хейжийн нягтлан бодох бүртгэлийг нэгтгэсэн санхүүгийн тайланд буцаах ёстой.

Үлгэрчлэн харуулвал: А байгууллагын төрийн сангийн хэлтэс нь уг байгууллагын өөр нэг хэлтэстэй дотоод хүүний түвшний свопын гэрээ байгуулсан. Зорилго нь зээлийн багц дахь зээлийн (эсвэл ижил төсөөтэй зээлүүдийн бүлгийн) хүүний түвшний эрсдэлд хейж хийх явдал юм. Уг свопын дагуу төрийн сангийн хэлтэс нь худалдааны хэлтэст тогтмол хувь хэмжээтэй хүү төлөх ба хариуд нь хувьсах хувь хэмжээтэй хүүний төлбөр хүлээн авна.

Хэрэв хейжийн хэрэглүүрийг гаднын талаас олж эзэмшээгүй бол уг төрийн сангийн хэлтэс ба бусад хэлтсүүдийн хийсэн хейжийн ажил гүйлгээнд хейжийн нягтлан бодох бүртгэлийн арга ашиглахыг УСНББОУС 29-өөр зөвшөөрөхгүй. Тухайн байгууллагын хувьд гадны этгээд болох тийм оролцогч тал бүхий зөвхөн тэдгээр хэрэглүүрийг хейжийн хэрэглүүр гэж сонгож болох бөгөөд нэг эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээнд эсвэл бие даасан байгууллагын доторх ажил гүйлгээний аливаа олз, гарзыг нэгтгэл хийх үед устгаж, цэвэрлэх хэрэгтэй гэж УСНББОУС 29-ийн 82-р параграфт заасан байдаг. Ийм учраас А байгууллагын доторх өөр өөр хэлтсүүдийн хооронд хийгдсэн ажил гүйлгээ нь тухайн А байгууллагын санхүүгийн тайлангийн хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангахгүй. Үүнтэй адилаар, эдийн засгийн нэгдмэл байгууллагад хамаарах өөр өөр байгууллагуудын хооронд хийгдсэн ажил гүйлгээ нь нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангахгүй юм.

Гэвч дээрх жишээнд уг хүүний түвшний свопоос гадна худалдааны хэлтэс нь хүүний свопоор хейж хийсэн эрсдлийг харилцан нөхөхийн тулд гаднын талтай хүүний түвшний свопын буюу бусад гэрээг байгуулсан бол УСНББОУС 29-ийн дагуу хейжийн нягтлан бодох бүртгэлийг зөвшөөрнө. УСНББОУС 29-ийн зорилгын хувьд хейжийн зүйл нь төрийн сангийн хэлтэс дэх зээл (эсвэл ижил төсөөтэй зээлүүдийн бүлэг), харин хейжийн хэрэглүүр нь гаднын хүүний түвшний своп буюу бусад гэрээ байна.

Худалдааны хэлтэс нь бие биенийгээ харилцан нөхдөггүй хэд хэдэн дотоод своп буюу тэдгээрийн хэсгийг нэгтгэн нийлүүлж, уг нэгдсэн эрсдлийг харилцан нөхөх гуравдагч талын нэг үүсмэл гэрээг байгуулж болох юм. Төрийн сангийн хэлтэст

хейжийн зүйлийг тодорхойлсон ба хейжийн нягтлан бодох бүртгэлийн бусад нөхцлүүд хангагдсан бол ийм гаднын хейжийн ажил гүйлгээ нь УСНББОУС 29-ын дагуу хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангаж болно. Гэвч хейж хийсэн эрсдэл нь хүүний түвшний өөрчлөлтийн эрсдэл бол дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийг УСНББОУС 29-ийн 82-р параграфтаар зөвшөөрдөггүй гэдгийг анхаарах хэрэгтэй.

**Е.1.5 Хүүний түвшний эрсдлийг удирдан зохицуулахад ашигласан дотоод үүсмэл гэрээг харилцан нөхөх**

**Хүүний түвшний эрсдлийг төвлөрсөн байдлаар удирдан зохицуулахын тулд төв төрийн сангийн хэлтэс нь уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээнд дэх хяналтанд буй байгууллагууд болон өөр өөр хэлтсүүдтэй дотоод үүсмэл гэрээг байгуулдаг тохиолдолд тэдгээр дотоод гэрээг юуны өмнө өөр хооронд нь харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах ба зөвхөн цэвэр эрсдлийг гаднын үүсмэл гэрээгээр харилцан нөхөж, эрсдлийг бууруулахаас өмнө эдгээр гэрээ нь нэгтгэсэн санхүүгийн тайланд хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангах уу?**

Үгүй. Хяналтанд буй байгууллагын түвшинд эсвэл хэлтсээр хейж гэж сонгосон дотоод гэрээ нь уг хейж хийж буй зүйлийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөхөд (бодит үнэ цэнийн хейж), харин дотоод үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрөхөд (мөнгөн гүйлгээний хейж) хүргэдэг. Эрсдлийг гаднын үүсмэл хэрэглүүрээр харилцан нөхөхөөс бусад тохиолдолд, бодит үнэ цэнийн хейжийн хувьд хейж хийж буй тухайн зүйлийн хэмжилтийн шинжийг өөрчлөх үндэслэлгүй юм. Түүнчлэн, эрсдлийг гаднын үүсмэл хэрэглүүрээр харилцан нөхөхөөс бусад тохиолдолд дотоод үүсмэл хэрэглүүрийн олз, гарзыг нэг байгууллагын хувьд цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрөх, харин нөгөө байгууллагын хувьд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх үндэслэлгүй билээ. Хяналтанд буй байгууллагын буюу хэлтсийн түвшинд хөрөнгө, өр төлбөрийн хүүний түвшний эрсдлийг удирдан зохицуулахын тулд хоёр буюу хэд хэдэн дотоод үүсмэл хэрэглүүрийг ашигладаг тохиолдолд тэдгээр дотоод үүсмэл хэрэглүүрүүдийг хейжийн хэрэглүүр гэж сонгохын үр нөлөө нь тухайн хяналтанд буй байгууллага буюу хэлтсийн түвшинд хейж хийсэн уг үүсмэл бус хэрэглүүрийн эрсдлийг нэгтгэсэн санхүүгийн тайлангийн түвшинд бие биенээр харилцан нөхөж, цэвэр дүн гаргахад ашиглах явдал юм. Гадаад валютын эрсдлээс бусад тохиолдолд үүсмэл бус хэрэглүүрийг хейжийн хэрэглүүр гэж сонгохыг УСНББОУС 29-ийн 81-р параграфтаар зөвшөөрдөггүй учраас гаднын талуудтай гэрээ байгуулаагүй уг дотоод үүсмэл хэрэглүүрийг тухайн хяналтанд буй байгууллага буюу хэлтсийн түвшинд ашигласнаар хийгдсэн хейжийн нягтлан бодох бүртгэлийн үр дүнг нэгтгэсэн санхүүгийн тайланд буцаах ёстой.

Гэвч дотоод үүсмэл хэрэглүүрийг уг хяналтанд буй байгууллага буюу хэлтсийн түвшинд нэг ижил төрлийн хейжийн харилцаанд ашигладаг бөгөөд мөнгөн гүйлгээний хейжийн хувьд тэрхүү хейжийн зүйлс нь тухайн тайлант үеийн ашиг, алдагдалд нөлөө үзүүлдэг бол нэгтгэлийн түвшинд бие биенийгээ харилцан нөхдөг тэдгээр дотоод үүсмэл хэрэглүүрийн хейжийн нягтлан бодох бүртгэлийн үр нөлөөг

нэгтгэсэн санхүүгийн тайланд буцааснаар ашиг, алдагдалд болон цэвэр хөрөнгө/өмчид нөлөө үзүүлэхгүй гэдгийг анхаарах хэрэгтэй. Төрийн сангийн түвшинд бие биенийгээ харилцан нөхдөг дотоод үүсмэл хэрэглүүртэй адилаар, уг нэгтгэсэн группын хүрээнд дэх тусдаа хоёр байгууллага буюу хэлтсүүд тэдгээр үүсмэл хэрэглүүрийг бодит үнэ цэнийн хейж байдлаар ашиглах нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэнийн дүнгүүдийг мөн харилцан нөхөхөд хүргэх бөгөөд тэрхүү эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээнд дэх тусдаа хоёр байгууллага буюу хэлтсүүд тэдгээр үүсмэл хэрэглүүрийг мөнгөн гүйлгээний хейж байдлаар ашиглах нь цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэнийн дүнгүүдийг мөн харилцан нөхөхөд хүргэнэ. Гэхдээ нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ба нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн аль алин дахь бие даасан мөрийн зүйлсэд нөлөө үзүүлж болох юм. Жишээлбэл; бодит үнэ цэнийн хейжийн хувьд хөрөнгөнд (буюу өр төлбөрт) хейж хийдэг дотоод үүсмэл хэрэглүүрийг тухайн санхүүгийн байдлын тайлан эсвэл цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлангийн өөр өөр мөрийн зүйлсэд хүлээн зөвшөөрсөн, өөр бусад хөрөнгийн (буюу өр төлбөрийн) бодит үнэ цэнийн хейж болгон ашигладаг дотоод үүсмэл хэрэглүүрээр харилцан нөхөх. Түүнчлэн, дотоод гэрээнүүдийн нэгийг мөнгөн гүйлгээний хейж байдлаар ашигладаг, нөгөөг нь бодит үнэ цэнийн хейжид ашигладаг тохиолдолд бодит үнэ цэнийн хейж болгон ашигладаг дотоод үүсмэл хэрэглүүрийн олз (буюу гарз)-ыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг ба мөнгөн гүйлгээний хейж болгон ашигладаг дотоод үүсмэл хэрэглүүрийн харгалзах олз (буюу гарз)-ыг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрдөг учраас тэдгээр хүлээн зөвшөөрсөн олз, гарз нь бие биенийгээ харилцан нөхөхгүй.

Дотоод хейжийн ажил гүйлгээнд УСНББОУС 29-ийг хэрхэн мөрдөхийг Асуулт Е.1.4-т авч үзсэн.

#### **Е.1.6 Гадаад валютын эрсдлийг удирдан зохицуулахад ашигласан дотоод үүсмэл гэрээг харилцан нөхөх**

**Гадаад валютын эрсдлийг төвлөрсөн байдлаар удирдан зохицуулахын тулд төв төрийн сангийн хэлтэс нь уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээнд дэх хяналтанд буй байгууллагууд болон өөр өөр хэлтсүүдтэй дотоод үүсмэл гэрээг байгуулдаг тохиолдолд тэдгээр дотоод гэрээг юуны өмнө өөр хооронд нь харилцан суутгаж, цэвэр дүнг гаргах ба зөвхөн цэвэр эрсдлийг гаднын үүсмэл гэрээгээр харилцан нөхөж, эрсдлийг бууруулахаас өмнө эдгээр гэрээг тухайн нэгтгэсэн санхүүгийн тайланд хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангах гаднын ажил гүйлгээг тодорхойлох суурь болгон ашиглаж болох уу?**

Нөхцөл байдлаас хамаарна. УСНББОУС 35 нь бүх дотоод ажил гүйлгээг нэгтгэсэн санхүүгийн тайланд устгаж, цэвэрлэхийг шаарддаг. УСНББОУС 29-ийн 82-р параграфт заасанчлан, дотоод хейжийн ажил гүйлгээ нь уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангадаггүй. Иймээс хэрэв байгууллага нь нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд хейжийн нягтлан бодох бүртгэл хийхийг хүсвэл тус байгууллага нь шалгуур хангах гаднын хейжийн хэрэглүүр ба шалгуур хангах хейжийн зүйлийн хооронд хейжийн харилцааг сонгох ёстой.

Асуулт Е.1.5-д авч хэлэлцсэнчлэн, хяналтанд буй байгууллагын буюу хэлтсийн түвшинд хүүний түвшний эрсдлийг удирдан зохицуулахын тулд ашигладаг бөгөөд төрийн сангийн түвшинд харилцан нөхдөг хоёр буюу хэд хэдэн дотоод үүсмэл хэрэглүүрийн нягтлан бодох бүртгэлийн үр нөлөө нь тухайн хяналтанд буй байгууллага буюу хэлтсийн түвшинд хейж хийсэн уг үүсмэл бус хэрэглүүрийн эрсдлийг нэгтгэсэн санхүүгийн тайлангийн түвшинд бие биенээр харилцан нөхөж, цэвэр дүн гаргахад ашиглах явдал байдаг. Хэрэв (а) дотоод үүсмэл хэрэглүүрийг нэг ижил төрлийн хейжийн (өөрөөр хэлбэл, бодит үнэ цэнийн эсвэл мөнгөн гүйлгээний хейжийн) харилцаанд ашигладаг, ба (б) мөнгөн гүйлгээний хейжийн хувьд цэвэр хөрөнгө/өмчид анх хүлээн зөвшөөрсөн аливаа үүсмэл хэрэглүүрийн олз, гарзыг тухайн тайлант үед ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг бол ашиг, алдагдалд эсвэл цэвэр хөрөнгө/өмчид үр нөлөө үзүүлэхгүй. Энэхүү хоёр нөхцөл хангагдах тохиолдолд ашиг, алдагдалд эсвэл цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн дотоод үүсмэл хэрэглүүрийн олз, гарз нь нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх үед харилцан нөхөгдөх бөгөөд ингэснээр уг үүсмэл хэрэглүүрүүдийг устгаж, цэвэрлэсэнтэй ижил ашиг, алдагдал болон цэвэр хөрөнгө/өмч бий болгох үр дүнтэй байдаг. Гэхдээ нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ба нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн аль алин дахь бие даасан мөрийн зүйлсэд нөлөө үзүүлж болох бөгөөд устгаж, цэвэрлэх шаардлагатай. Түүнчлэн, харилцан нөхөх дотоод үүсмэл хэрэглүүрүүдийн заримыг мөнгөн гүйлгээний хейжид, өөр заримыг бодит үнэ цэнийн хейжид ашигладаг бол ашиг, алдагдалд болон цэвэр хөрөнгө/өмчид нөлөө үзүүлнэ. Цэвэр хөрөнгө/өмчид анх хүлээн зөвшөөрсөн үүсмэл хэрэглүүрийн олз, гарзыг (уг хейжийн зүйл нь өөр өөр тайлант үеүдийн ашиг, алдагдалд нөлөөлдөг учраас) өөр өөр тайлант үед ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг бол мөнгөн гүйлгээний хейжид ашигладаг тэдгээр харилцан нөхөх дотоод үүсмэл хэрэглүүрүүдийн хувьд ашиг, алдагдалд болон цэвэр хөрөнгө/өмчид мөн үр нөлөө үзүүлнэ.

УСНББОУС 29-ийн 81-р параграф нь хейжийн нягтлан бодох бүртгэлийн зорилгоор үүсмэл бус санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг гадаад валютын эрсдлийн хейжид хейжийн хэрэглүүр гэж сонгохыг зөвшөөрдөг учраас гадаад валютын эрсдлийн хувьд, уг дотоод үүсмэл хэрэглүүр нь үүсмэл бус суурь санхүүгийн хөрөнгө буюу өр төлбөрийн гадаад валютын эрсдлийн шилжүүлэлтийг илэрхийлдэг бол хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэж болно. Иймээс энэ тохиолдолд дотоод үүсмэл гэрээнүүд нь бие биенийгээ харилцан нөхөх боловч нэгтгэсэн санхүүгийн тайланд хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангах гаднын ажил гүйлгээг тодорхойлох суурь болгон тэдгээр дотоод үүсмэл хэрэглүүрийг ашиглаж болно. Гэвч нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд зөвхөн гаднын ажил гүйлгээг хамруулан оруулах тийм хейжийн харилцааг сонгох шаардлагатай.

Түүнчлэн, харилцан нөхөх хоёр буюу хэд хэдэн дотоод үүсмэл хэрэглүүрүүд нь урьдчилан таамагласан суурь ажил гүйлгээ эсвэл хүлээн зөвшөөрөөгүй арилжааны баталгааны хувьд гадаад валютын эрсдлийн шилжилтийг илэрхийлдэг тохиолдолд байгууллага нь хейжийн нягтлан бодох бүртгэлийг мөрдөж болохгүй. Яагаад гэвэл, хүлээн зөвшөөрөөгүй арилжааны баталгаа болон урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь УСНББОУС 29-ийн дагуу хейжийн хэрэглүүрийн шалгуурыг хангадаггүй. Ингэснээр энэ тохиолдолд нэгтгэсэн санхүүгийн тайланд хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангах гаднын ажил гүйлгээг тодорхойлох суурь болгон тэдгээр дотоод үүсмэл хэрэглүүрийг ашиглаж болохгүй. Иймээс харилцан нөхөх

дотоод үүсмэл хэрэглүүр нь санхүүгийн хөрөнгө буюу өр төлбөрийн гадаад валютын эрсдлийг гаднын хейжийн хэрэглүүрт шилжүүлэх тийм шилжүүлэлтийг төлөөлөн илэрхийлсэн гэдгийг батлан харуулж чадахгүй бол тухайн хөрөнгө, өр төлбөрийн анхны дансны үнэд тусгасан (суурийн тохируулга) эсвэл цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн, уг дотоод үүсмэл хэрэглүүрийн аливаа хуримтлагдсан цэвэр олз буюу гарзыг нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх үед буцаах ёстой.

### Е.1.7 Дотоод үүсмэл хэрэглүүр: Асуулт Е.1.6-г хэрэглэх жишээ

*Жишээ бүрийн хувьд ГВ=гадаад валют, ОНВ=орон нутгийн валют (энэ нь тухайн байгууллагын бүртгэлийн валют), ТС=төрийн сан гэсэн утгатай байна.*

#### *Жишээ 1: Бодит үнэ цэнийн хейжийн харилцан нөхөлт*

А хяналтанд буй байгууллага нь 60 хоногийн дотор төлөгдөх 100 ГВ-ын худалдааны авлагатай бөгөөд ТС-тай байгуулсан форвард гэрээг ашигласнаар үүнд хейж хийдэг. Б хяналтанд буй байгууллага нь мөн 60 хоногийн дотор төлөх 50 ГВ-ын өглөгтэй бөгөөд ТС-тай байгуулсан форвард гэрээг ашигласнаар үүнд хейж хийдэг.

ТС нь энэхүү хоёр дотоод үүсмэл хэрэглүүрийн цэвэр дүнг гаргаж, 60 хоногийн дараа 50 ГВ төлөх ба ОНВ хүлээн авах гаднын цэвэр форвард гэрээг байгуулсан.

1 дэх сарын эцэст ГВ-ын ОНВ-тай харьцах ханш суларсан. А байгууллага нь өөрийн авлагын хувьд 10 ОНВ-ын ханшийн гарз хүлээсэн ба түүнийг ТС-тай байгуулсан форвард гэрээний 10 ОНВ-ын олзоор нөхнө. Б байгууллага нь өөрийн өглөгийн хувьд 5 ОНВ-ын ханшийн олз олсон ба энэ нь ТС-тай байгуулсан форвард гэрээнээс хүлээх 5 ОНВ-ын ханшийн гарзаар нөхөгдөнө. ТС нь А байгууллагатай байгуулсан дотоод форвард гэрээнээс 10 ОНВ-ын гарз хүлээсэн ба Б байгууллагатай байгуулсан дотоод форвард гэрээнээс 5 ОНВ-ын олз, мөн өөрийн гаднын форвард гэрээнээс 5 ОНВ олз олжээ.

1 дэх сарын эцэст, А, Б байгууллага болон ТС-ийн бие даасан буюу тусдаа санхүүгийн тайлангуудад дараах дансны бичилт хийнэ. Уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх ажил гүйлгээ буюу үйл явдлуудыг тусгах дансны бичилтүүдийг ташуу үсгээр харуулсан.

#### **А байгууллагын дансны бичилтүүд:**

Дебит	Ханшийн гарз	10 ОНВ	
Кредит	Авлага		10 ОНВ
<i>Дебит</i>	<i>Дотоод гэрээ-ТС</i>	<i>10 ОНВ</i>	
<i>Кредит</i>	<i>Дотоод олз-ТС</i>		<i>10 ОНВ</i>

#### **Б байгууллагын дансны бичилтүүд:**

Дебит	Өглөг	5 ОНВ	
Кредит	Ханшийн олз		5 ОНВ

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

<i>Дебит</i>	<i>Дотоод гарз-ТС</i>	5 ОНВ	
<i>Кредит</i>	<i>Дотоод гэрээ-ТС</i>		5 ОНВ
<b>ТС-гийн дансны бичилтүүд:</b>			
<i>Дебит</i>	<i>Дотоод гарз-А</i>	10 ОНВ	
<i>Кредит</i>	<i>Дотоод гэрээ-А</i>		10 ОНВ
<i>Дебит</i>	<i>Дотоод гэрээ-Б</i>	5 ОНВ	
<i>Кредит</i>	<i>Дотоод олз-Б</i>		5 ОНВ
Дебит	Гаднын форвард гэрээ	5 ОНВ	
Кредит	Ханшийн олз		5 ОНВ

Хэрэв УСНББОУС 29-д заасан бүх нөхцлүүд биелвэл А ба Б байгууллагын аль аль нь өөрсдийн бие даасан санхүүгийн тайландаа хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэж болно. Гэвч дотоод үүсмэл хэрэглүүрүүдийн олз, гарз болон уг хейж хийсэн авлага, өглөгийн харилцан нөхөгдөх гарз, олзыг хейжийн нягтлан бодох бүртгэлгүйгээр А ба Б байгууллагын ашиг, алдагдалд нэн даруй хүлээн зөвшөөрөх учраас энэ тохиолдолд хейжийн нягтлан бодох бүртгэл шаардлагагүй.

Нэгтгэсэн санхүүгийн тайланд, дотоод үүсмэл хэрэглүүрийн ажил гүйлгээг устгаж цэвэрлэдэг. Эдийн засгийн утгаараа, Б байгууллагын өглөг нь А байгууллагын 50 ГВ-ын авлагад хейж хийдэг. ТС-ын гаднын форвард гэрээ нь А байгууллагын үлдсэн 50 ГВ-ын авлагад хейж хийнэ. Хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэсэн эсэхээс үл хамааран мөнгөн зүйлсийг УСНББОУС 4-ийн дагуу гадаад валютын спот ханшаар хэмждэг учраас нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд хейжийн нягтлан бодох бүртгэл шаардлагагүй юм.

Дотоод үүсмэл хэрэглүүртэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн бичилтүүдийн устгалтын өмнөх ба дараах цэвэр үлдэгдэл нь доор харуулсанчлан, ижил байна. Иймээс УСНББОУС 29-ийн шаардлагуудыг хангахын тулд цаашид аливаа нягтлан бодох бүртгэлийн бичилтүүд хийх шаардлагагүй юм.

	<i>Дебит</i>	<i>Кредит</i>
Авлага	-	10 ОНВ
Өглөг	5 ОНВ	-
Гаднын форвард гэрээ	5 ОНВ	-
Олз ба гарз	-	-
Дотоод гэрээ	-	-

**Жишээ 2: Мөнгөн гүйлгээний хейжийн харилцан нөхөлт**

Дээрх жишээг үргэлжүүлэн авч үзье. А байгууллага нь өндөр магадлалтай, 200 ГВ-ын ирээдүйн орлоготой бөгөөд үүнээс 90 хоногийн дараа мөнгө авна гэж бас хүлээж байна. Б байгууллага нь мөн 90 хоногийн дараа төлөх, өндөр магадлалтай, 500 ГВ-ын ирээдүйн зардалтай (оффисын түрээсийн зардал). А ба Б байгууллагууд нь эдгээр эрсдэлд хейж хийхийн тулд ТС-тай тусдаа форвард гэрээ байгуулсан бөгөөд ТС нь 90 хоногийн дараа 300 ГВ хүлээн авах гаднын форвард гэрээг байгуулсан.

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

Өмнөх жишээтэй адилаар, 1 дэх сарын эцэст ГВ-ын ханш суларсан. Эдгээр орлогын ОНВ-ын үнэ цэнэ буурсан учраас А байгууллага нь өөрийн урьдчилан таамагласан орлогын хувьд 20 ОНВ-ын “гарз” хүлээсэн. Энэхүү гарз нь ТС-тай байгуулсан түүний форвард гэрээний 20 ОНВ-ын “олз”-оор харилцан нөхөгдөнө.

Тухайн зардлын ОНВ-ын үнэ цэнэ буурсан учраас Б байгууллага нь өөрийн урьдчилан таамагласан зар сурталчилгааны зардлын хувьд 50 ОНВ-ын “олз” олсон. Энэхүү олз нь ТС-тай байгуулсан түүний ажил гүйлгээний 50 ОНВ-ын “гарз”-аар харилцан нөхөгдөнө.

ТС нь Б байгууллагатай хийсэн дотоод ажил гүйлгээнээс 50 ОНВ-ын “олз” олсон, харин А байгууллагатай хийсэн дотоод ажил гүйлгээнээс 20 ОНВ-ын “гарз”, өөрийн гаднын форвард гэрээнээс 30 ОНВ-ын гарз тус тус хүлээсэн.

А ба Б байгууллага нь шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлсэн, хейж нь үр дүнтэй бөгөөд А, Б байгууллагын аль аль нь өөрсдийн бие даасан санхүүгийн тайландаа хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангадаг. А байгууллага нь дотоод үүсмэл хэрэглүүрийн ажил гүйлгээнээс олсон 20 ОНВ-ын олзыг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрөх ба Б байгууллага нь 50 ОНВ-ын гарзыг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн. ТС нь хейжийн нягтлан бодох бүртгэл хийх шаардлагагүй боловч өөрийн дотоод ба гадаад үүсмэл хэрэглүүрийн аль алины төлөв байдлыг бодит үнэ цэнээр хэмжих бөгөөд энэ нь цэвэр дүнгээрээ тэг (0) байна.

1 дэх сарын эцэст, А, Б байгууллага болон ТС-ийн бие даасан буюу тусдаа санхүүгийн тайлангуудад дараах дансны бичилт хийнэ. Уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх ажил гүйлгээ буюу үйл явдлуудыг тусгах дансны бичилтүүдийг ташуу үсгээр харуулсан.

**А байгууллагын дансны бичилтүүд:**

<i>Дебит</i>	<i>Дотоод гэрээ-ТС</i>	20 ОНВ	
<i>Кредит</i>	<i>Цэвэр хөрөнгө/өмч</i>		20 ОНВ

**Б байгууллагын дансны бичилтүүд:**

<i>Дебит</i>	<i>Цэвэр хөрөнгө/өмч</i>	50 ОНВ	
<i>Кредит</i>	<i>Дотоод гэрээ-ТС</i>		50 ОНВ

**ТС-гийн дансны бичилтүүд:**

<i>Дебит</i>	<i>Дотоод гарз-А</i>	20 ОНВ	
<i>Кредит</i>	<i>Дотоод гэрээ-А</i>		20 ОНВ

<i>Дебит</i>	<i>Дотоод гэрээ-Б</i>	50 ОНВ	
<i>Кредит</i>	<i>Дотоод олз-Б</i>		50 ОНВ

<i>Дебит</i>	<i>Ханшийн гарз</i>	30 ОНВ	
<i>Кредит</i>	<i>Гаднын форвард гэрээ</i>		30 ОНВ



## САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд, 1 дэх сарын эхэнд ТС-гийн 300 ГВ-ын гаднын форвард гэрээг Б байгууллагын өндөр магадлалтай ирээдүйн зардлын эхний 300 ГВ-ын хейжийн хэрэглүүр гэж сонгосон. УСНББОУС 29 нь 1 дэх сарын эцэст уг дотоод үүсмэл хэрэглүүрийн ажил гүйлгээний нягтлан бодох бүртгэлийн үр нөлөөг тухайн нэгтгэсэн санхүүгийн тайланд устгаж, цэвэрлэхийг шаардаг.

Гэвч дотоод үүсмэл хэрэглүүртэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн бичилтүүдийн устгалтын өмнөх ба дараах цэвэр үлдэгдэл нь доор харуулсанчлан, ижил байна. Иймээс УСНББОУС 29-ийн шаардлагуудыг хангахын тулд цаашид аливаа нягтлан бодох бүртгэлийн бичилтүүд хийх шаардлагагүй юм.

	<i>Дебит</i>	<i>Кредит</i>
Гаднын форвард гэрээ	-	30 ОНВ
Цэвэр хөрөнгө/өмч	30 ОНВ	-
Олз ба гарз	-	-
Дотоод гэрээ	-	-

### *Жишээ 3: Бодит үнэ цэнийн болон мөнгөн гүйлгээний хейжийн харилцан нөхөлт*

Эрсдэл ба дотоод үүсмэл хэрэглүүрүүдийн ажил гүйлгээ нь Жишээ 1 ба 2-т дурдсантай ижил гэж үзье. Гэвч бодит үнэ цэнийн болон мөнгөн гүйлгээний эрсдэлд тус тусад нь хейж хийхийн тулд энэхүү хоёр гаднын үүсмэл хэрэглүүрүүдийн гэрээ байгуулахын оронд ТС нь ОНВ-ын хариуд 90 хоногийн дараа 250 ГВ хүлээн авах нэг цэвэр гаднын үүсмэл хэрэглүүрийн гэрээ байгуулсан.

ТС нь дөрвөн дотоод үүсмэл хэрэглүүртэй бөгөөд үүнээс хоёр нь 60 хоногийн дараа, үлдсэн хоёр нь 90 хоногийн дараа дуусгавар болно. 90 хоногийн дараа дуусгавар болох, гаднын цэвэр үүсмэл хэрэглүүрээр эдгээрийг харилцан нөхдөг. ГВ ба ОНВ-ын хоорондох хүүний түвшний зөрүү бага, иймээс дуусгавар болох хугацааны уялдаагүй байдлаас шалтгаалах үр дүнгүй байдал нь ТС-гийн ашиг, алдагдалд маш бага үр нөлөөтэй гэж үзэж байна.

Жишээ 1 ба 2-т дурдсантай адилаар, А ба Б байгууллага нь өөрсдийн мөнгөн гүйлгээний хейжийн хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэх бөгөөд ТС нь өөрийн үүсмэл хэрэглүүрүүдийг бодит үнэ цэнээр хэмжинэ. А байгууллага нь өөрийн дотоод үүсмэл хэрэглүүрийн ажил гүйлгээнээс үүсэх 20 ОНВ-ын олзыг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө, харин Б байгууллага нь өөрийн дотоод үүсмэл хэрэглүүрийн ажил гүйлгээний 50 ОНВ-ын гарзыг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө.

1 дэх сарын эцэст, А, Б байгууллага болон ТС-ийн бие даасан буюу тусдаа санхүүгийн тайлангуудад дараах дансны бичилт хийнэ. Уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх ажил гүйлгээ буюу үйл явдлуудыг тусгах дансны бичилтүүдийг ташуу үсгээр харуулсан.

**А байгууллагын дансны бичилтүүд:**

Дебит	Ханшийн гарз	10 ОНВ	
Кредит	Авлага		10 ОНВ
Дебит	Дотоод гэрээ-ТС	10 ОНВ	
Кредит	Дотоод олз-ТС		10 ОНВ
Дебит	Дотоод гэрээ-ТС	20 ОНВ	
Кредит	Цэвэр хөрөнгө/өмч		20 ОНВ

**Б байгууллагын дансны бичилтүүд:**

Дебит	Өглөг	5 ОНВ	
Кредит	Ханшийн олз		5 ОНВ
Дебит	Дотоод гарз-ТС	5 ОНВ	
Кредит	Дотоод гэрээ-ТС		5 ОНВ
Дебит	Цэвэр хөрөнгө/өмч	50 ОНВ	
Кредит	Дотоод гэрээ-ТС		50 ОНВ

**ТС-гийн дансны бичилтүүд:**

Дебит	Дотоод гарз-А	10 ОНВ	
Кредит	Дотоод гэрээ-А		10 ОНВ
Дебит	Дотоод гарз-А	20 ОНВ	
Кредит	Дотоод гэрээ-А		20 ОНВ
Дебит	Дотоод гэрээ-Б	5 ОНВ	
Кредит	Дотоод олз-Б		5 ОНВ
Дебит	Дотоод гэрээ-Б	50 ОНВ	
Кредит	Дотоод олз-Б		50 ОНВ
Дебит	Ханшийн гарз	25 ОНВ	
Кредит	Гаднын форвард гэрээ		25 ОНВ

НИЙТ ДҮН (дотоод үүсмэл хэрэглүүрийн хувьд)	А	В	Дүн
	ОНВ	ОНВ	ТС
Ашиг, алдагдал (бодит үнэ цэнийн хейж)	10	(5)	5
Цэвэр хөрөнгө/өмч (мөнгөн гүйлгээний хейж)	20	(50)	(30)
Нийт дүн	30	(55)	(25)

Эдгээр дүнгүүдийг гаднын ажил гүйлгээтэй (өөрөөр хэлбэл, дээр ташуу үсгээр илэрхийлээгүй) нэгтгэн нийлүүлэх нь уг дотоод үүсмэл хэрэглүүрүүдийн устгалтын өмнөх нийт цэвэр үлдэгдлийг дараах байдалтай болгоно:

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

	<i>Дебит</i>	<i>Кредит</i>
Авлага	-	10 ОНВ
Өглөг	5 ОНВ	-
Форвард гэрээ	-	25 ОНВ
Цэвэр хөрөнгө/өмч	30 ОНВ	-
Олз ба гарз	-	-
Дотоод гэрээ	-	-

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд 1 дэх сарын эхэнд дараах сонголтуудыг хийсэн:

- Б байгууллагын 50 ГВ-ын өглөгийг А байгууллагын өндөр магадлалтай ирээдүйн орлогын эхний 50 ГВ-ын хейж гэж сонгосон. Иймээс 1 дэх сарын эцэст, тухайн нэгтгэсэн санхүүгийн тайланд дараах дансны бичилт хийнэ: Дт Өглөг 5 ОНВ, Кт Цэвэр хөрөнгө/өмч 5 ОНВ;
- А байгууллагын 100 ГВ-ын авлагыг Б байгууллагын өндөр магадлалтай ирээдүйн зардлын эхний 100 ГВ-ын хейж гэж сонгосон. Иймээс 1 дэх сарын эцэст, тухайн нэгтгэсэн санхүүгийн тайланд дараах дансны бичилт хийнэ: Дт Цэвэр хөрөнгө/өмч 10 ОНВ, Кт Авлага 10 ОНВ;
- ТС-гийн 250 ГВ-ын гаднын форвард гэрээг Б байгууллагын өндөр магадлалтай ирээдүйн зардлын дараагийн 250 ГВ-ын хейж гэж сонгосон. Иймээс 1 дэх сарын эцэст, тухайн нэгтгэсэн санхүүгийн тайланд дараах дансны бичилт хийнэ: Дт Цэвэр хөрөнгө/өмч 25 ОНВ; Кт Гаднын форвард гэрээ 25 ОНВ.

УСНББОУС 29 нь 1 дэх сарын эцэст уг дотоод үүсмэл хэрэглүүрийн ажил гүйлгээний нягтлан бодох бүртгэлийн үр нөлөөг тухайн нэгтгэсэн санхүүгийн тайланд устгаж, цэвэрлэхийг шаардаг.

Гэвч дотоод үүсмэл хэрэглүүртэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн бичилтүүдийн устгалтын өмнөх ба дараах цэвэр үлдэгдэл нь доор харуулсанчлан, ижил байна. Иймээс УСНББОУС 29-ийн шаардлагуудыг хангахын тулд цаашид аливаа нягтлан бодох бүртгэлийн бичилтүүд хийх шаардлагагүй юм.

	<i>Дебит</i>	<i>Кредит</i>
Авлага	-	10 ОНВ
Өглөг	5 ОНВ	-
Форвард гэрээ	-	25 ОНВ
Цэвэр хөрөнгө/өмч	30 ОНВ	-
Олз ба гарз	-	-
Дотоод гэрээ	-	-

*Жишээ 4: Бараа материалын дансны үнийн тохируулга бүхий бодит үнэ цэнийн болон мөнгөн гүйлгээний хейжийн харилцан нөхөлт*

Б байгууллагын 500 ГВ-ын урьдчилан таамагласан мөнгөн зарлага нь 60 хоногийн дараа нийлүүлэх бараа материалын худалдан авалттай холбоотой гэдгээс бусад нь жишээ 3-ын ажил гүйлгээтэй ижил гэж үзье. Мөн байгууллага нь хейж хийсэн,

урьдчилан таамагласан санхүүгийн бус зүйлсэд суурийн тохируулга хийх бодлоготой гэж үзье. 2 дахь сарын эцэст, валютын ханшид эсвэл бодит үнэ цэнэд цаашид өөрчлөлт гараагүй. 1 дэх сард цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрч байсан, Б байгууллагын дотоод үүсмэл хэрэглүүрийн 50 ОНВ-ын гарзыг тэрхүү бараа материалыг хүргэн нийлүүлсэн өдөр Б байгууллагын бараа материалын дансны үнэд тохируулна. А байгууллагын дотоод үүсмэл хэрэглүүрийн 20 ОНВ-ын олзыг өмнөхтэй адилаар цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө.

Хейжийг буцаах ба дахин сонгосноор бий болох байсан үр дүнтэй харьцуулахад тухайн нэгтгэсэн санхүүгийн тайланд одоо уялдаагүй байдал үүснэ. Гаднын үүсмэл хэрэглүүр (250 ГВ) ба авлагын тодорхой хэсэг (50 ГВ) нь уг урьдчилан таамагласан бараа материалын худалдан авалтын 300 ГВ-ыг харилцан нөхнө. Б байгууллагын урьдчилан таамагласан мөнгөн зарлагын үлдсэн 200 ГВ-ын зардал ба А байгууллагын урьдчилан таамагласан 200 ГВ-ын мөнгөн орлогын хооронд ердийн хейжийн харилцаа үүснэ. Энэхүү харилцаа нь УСНББОУС 29-ийн дагуу хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангахгүй бөгөөд энэ тохиолдолд эдгээр дүнд хейж хийж буй уг дотоод үүсмэл хэрэглүүрүүдийн олз ба гарзын хооронд зөвхөн хэсэгчилсэн харилцан нөхөлт үүснэ.

1 ба 2 дахь сарын эцэст, А, Б байгууллага болон ТС-ийн бие даасан буюу тусдаа санхүүгийн тайлангуудад дараах дансны бичилт хийнэ. Уг эдийн засгийн нэгдмэл байгууллагын хүрээн дэх ажил гүйлгээ буюу үйл явдлуудыг тусгах дансны бичилтүүдийг ташуу үсгээр харуулсан.

**А байгууллагын дансны бичилтүүд:**

Дебит	Ханшийн гарз	10 ОНВ	
Кредит	Авлага		10 ОНВ
<i>Дебит</i>	<i>Дотоод гэрээ-ТС</i>	<i>10 ОНВ</i>	
<i>Кредит</i>	<i>Дотоод олз-ТС</i>		<i>10 ОНВ</i>
<i>Дебит</i>	<i>Дотоод гэрээ-ТС</i>	<i>20 ОНВ</i>	
<i>Кредит</i>	<i>Цэвэр хөрөнгө/өмч</i>		<i>20 ОНВ</i>

**Б байгууллагын дансны бичилтүүд:**

1 дэх сарын эцэст:

Дебит	Өглөг	5 ОНВ	
Кредит	Ханшийн олз		5 ОНВ
<i>Дебит</i>	<i>Дотоод гарз-ТС</i>	<i>5 ОНВ</i>	
<i>Кредит</i>	<i>Дотоод гэрээ-ТС</i>		<i>5 ОНВ</i>
<i>Дебит</i>	<i>Цэвэр хөрөнгө/өмч</i>	<i>50 ОНВ</i>	
<i>Кредит</i>	<i>Дотоод гэрээ-ТС</i>		<i>50 ОНВ</i>

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

2 дахь сарын эцэст:

Дебит	Бараа материал	50 ОНВ	
Кредит	Цэвэр хөрөнгө/өмч		50 ОНВ

**ТС-гийн дансны бичилтүүд (бүгд 1 дэх сарын эцэст):**

Дебит	Дотоод гарз-А	10 ОНВ	
Кредит	Дотоод гэрээ-А		10 ОНВ
Дебит	Дотоод гарз-А	20 ОНВ	
Кредит	Дотоод гэрээ-А		20 ОНВ
Дебит	Дотоод гэрээ-Б	5 ОНВ	
Кредит	Дотоод олз-Б		5 ОНВ
Дебит	Дотоод гэрээ-Б	50 ОНВ	
Кредит	Дотоод олз-Б		50 ОНВ
Дебит	Ханшийн гарз	25 ОНВ	
Кредит	Гаднын форвард гэрээ		25 ОНВ

НИЙТ ДҮН (дотоод үүсмэл хэрэглүүрийн хувьд)	А	В	Дүн
	ОНВ	ОНВ	ТС
Ашиг, алдагдал (бодит үнэ цэнийн хейж)	10	(5)	5
Цэвэр хөрөнгө/өмч (мөнгөн гүйлгээний хейж)	20	-	20
Суурийн тохируулга (бараа материал)	-	(50)	(50)
Нийт дүн	30	(55)	(25)

Эдгээр дүнгүүдийг гаднын ажил гүйлгээтэй (өөрөөр хэлбэл, дээр ташуу үсгээр илэрхийлээгүй) нэгтгэн нийлүүлэх нь уг дотоод үүсмэл хэрэглүүрүүдийн устгалтын өмнөх нийт цэвэр үлдэгдлийг дараах байдалтай болгоно:

	Дебит	Кредит
Авлага	-	10 ОНВ
Өглөг	5 ОНВ	-
Форвард гэрээ	-	25 ОНВ
Цэвэр хөрөнгө/өмч	-	20 ОНВ
Суурийн тохируулга (бараа материал)	50 ОНВ	-
Олз ба гарз	-	-
Дотоод гэрээ	-	-

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд 1 дэх сарын эхэнд дараах сонголтуудыг хийсэн:

- Б байгууллагын 50 ГВ-ын өглөгийг А байгууллагын өндөр магадлалтай ирээдүйн орлогын эхний 50 ГВ-ын хейж гэж сонгосон. Иймээс 1 дэх сарын эцэст, тухайн нэгтгэсэн санхүүгийн тайланд дараах дансны бичилт хийнэ: Дт Өглөг 5 ОНВ, Кт Цэвэр хөрөнгө/өмч 5 ОНВ;

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

- А байгууллагын 100 ГВ-ын авлагыг Б байгууллагын өндөр магадлалтай ирээдүйн зардлын эхний 100 ГВ-ын хейж гэж сонгосон. Иймээс 1 дэх сарын эцэст, тухайн нэгтгэсэн санхүүгийн тайланд дараах дансны бичилт хийнэ: Дт Цэвэр хөрөнгө/өмч 10 ОНВ, Кт Авлага 10 ОНВ; 2 дахь сарын эцэст Дт Бараа материал 10 ОНВ, Кт Цэвэр хөрөнгө/өмч 10 ОНВ.
- ТС-гийн 250 ГВ-ын гаднын форвард гэрээг Б байгууллагын өндөр магадлалтай ирээдүйн зардлын дараагийн 250 ГВ-ын хейж гэж сонгосон. Иймээс 1 дэх сарын эцэст, тухайн нэгтгэсэн санхүүгийн тайланд дараах дансны бичилт хийнэ: Дт Цэвэр хөрөнгө/өмч 25 ОНВ; Кт Гаднын форвард гэрээ 25 ОНВ; 2 дахь сарын эцэст Дт Бараа материал 25 ОНВ, Кт Цэвэр хөрөнгө/өмч 25 ОНВ.

Дотоод үүсмэл хэрэглүүртэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн бичилтүүдийн устгалтын дараах нийт цэвэр үлдэгдэл нь дараах байдалтай байна:

	<i>Дебит</i>	<i>Кредит</i>
Авлага	-	10 ОНВ
Өглөг	5 ОНВ	-
Форвард гэрээ	-	25 ОНВ
Цэвэр хөрөнгө/өмч	-	5 ОНВ
Суурийн тохируулга (бараа материал)	35 ОНВ	-
Олз ба гарз	-	-
Дотоод гэрээ	-	-

Эдгээр нийт цэвэр үлдэгдлүүд нь уг дотоод үүсмэл хэрэглүүрүүдийг устгаж, цэвэрлээгүй бол хүлээн зөвшөөрөх байсан дүнгүүдээс өөр бөгөөд тухайн нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгахыг УСНББОУС 29-өөр шаардах тийм цэвэр үлдэгдлүүд байна. Дотоод үүсмэл хэрэглүүрүүдийг устгаж, цэвэрлэхийн өмнөх нийт цэвэр үлдэгдлийг тохируулахад шаардлагатай нягтлан бодох бүртгэлийн бичилтүүд дараах байдалтай байна:

- Бараа материалын урьдчилан таамагласан худалдан авалтын 150 ГВ-д гаднын хэрэглүүрээр (ТС-гийн 250 ГВ-ын гаднын форвард гэрээгээр ч, А байгууллагын 100 ГВ-ын гаднын өглөгөөр ч) хейж хийгээгүй гэдгийг тусган харуулахын тулд бараа материалын дүнд оруулсан уг Б байгууллагын дотоод үүсмэл хэрэглүүрийн 15 ОНВ-ын гарзыг дахин ангилах; ба
- Урьдчилан таамагласан орлогын 150 ГВ-д гаднын хэрэглүүрээр хейж хийгээгүй гэдгийг тусган харуулахын тулд түүнд хамаарах А байгууллагын дотоод үүсмэл хэрэглүүрийн 15 ОНВ-ын олзыг дахин ангилах.

Энэхүү хоёр тохируулгын цэвэр үр нөлөө нь дараах байдалтай байна:

Дебит	Цэвэр хөрөнгө/өмч	15 ОНВ	
Кредит	Бараа материал		15 ОНВ

### Е.1.8 Гаргасан ба худалдан авсан опционы хослол

**Ихэнх тохиолдолд УСНББОУС 29-ийн МЗУ127-р параграф нь гаргасан опционыг хейжийн хэрэглүүр байдлаар ашиглахыг хориглодог. Хэрэв гаргасан опцион ба худалдан авсан опционы хослол (хүүний түвшний баталгаа гэх мэт)-ыг нэг оролцогч талтай ганц хэрэглүүр байдлаар ажил гүйлгээ хийсэн бол байгууллага нь уг үүсмэл хэрэглүүрийг түүний гаргасан опционы бүрэлдэхүүн хэсэг ба худалдан авсан опционы бүрэлдэхүүн хэсгээр задалж, тэрхүү худалдан авсан опционы бүрэлдэхүүн хэсгийг хейжийн хэрэглүүр гэж сонгож болох уу?**

Үгүй. Байгууллага нь хейжийн харилцааг тухайн хейжийн хэрэглүүрийн хувьд бүхэлд нь сонгоно гэж УСНББОУС 29-ийн 83-р параграфт тусгайлан заасан. Зөвшөөрөгдсөн гажих тохиолдлууд нь зөвхөн опционы цаг хугацааны үнэ цэнэ ба дотоод үнэ цэнийг салгах, форвард гэрээний хүүний элемент ба спот үнийг салгах явдал юм. Опционы хослолыг гаргасан опцион гэж үзэх эсэх, хэдийд тэгж үзэх эсэхийг Асуулт Е.1.3-д авч хэлэлцсэн.

### Е.1.9 Тэг дельта бүхий хейжийн стратеги

**Хейжийн хүссэн харьцааг хадгалах, тухайлбал уг хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөнд мэдрэмжгүй тэг (0) дельта төлөв байдалд хүрэхийн тулд хейжийн хэрэглүүрийн тоо хэмжээг байнга тохируулдаг “тэг-дельта” хейжийн стратеги<sup>19</sup> болон бусад идэвхитэй стратегийн хувьд байгууллага нь хейжийн нягтлан бодох бүртгэл хэрэглэхийг УСНББОУС 29-өөр зөвшөөрдөг үү?**

Тийм. “Опционы гэрээний дотоод үнэ цэнэ ба цаг хугацааны үнэ цэнийн аль алиныг үнэлдэг хейжийн идэвхитэй стратеги нь хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангана” гэж УСНББОУС 29-ийн 83-р параграфт заасан. Жишээлбэл; тухайн хейжийн зүйлийн бодит үнэ цэнэ нь нэмэгдэхийг зөвшөөрөх боловч тодорхой түвшнээс буурахгүй байлгахыг эрмэлздэг даатгалын багц гэрээний стратеги нь хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангаж болох юм.

Хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангахын тулд байгууллага нь тухайн хейжийн хэрэглүүрийн бүх дуусгавар болголт ба дахин сонголтыг зохих ёсоор хөтлөх, түүнчлэн УСНББОУС 29-ийн 98-р параграфт заасан хейжийн нягтлан бодох бүртгэлийн бусад бүх шалгуур хангагдсан гэдгийг батлан харуулах боломжтой болох үүднээс уг хейжийг хэрхэн хянан үнэлж, баяжуулах ба хейжийн үр дүнтэй байдлыг хэмжихээ баримтжуулах ёстой. Мөн байгууллага нь тухайн хейжид тохируулга хийх шаардлагагүй гэж үзэж буй тодорхой богино хугацааны туршид тэрхүү хейж өндөр үр дүнтэй байна гэсэн хүлээлтээ батлан харуулах боломжтой байх ёстой.

<sup>19</sup> Дельта гэдэг нь суурь үнэт цаасны үнэ өөрчлөгдөх үед опционы үнэ хэрхэн өөрчлөгдөхийг хэмждэг коэффициент бөгөөд Грек цагаан толгойн дельта ( $\Delta$ ) үсгээр тэмдэглэдэг. Тэг (буюу нейтраль) дельта гэдэг нь тухайн авч үзэж буй санхүүгийн хөрөнгүүдийн ерөнхий дельтаг тэг болгохын тулд зерэг ба сөрөг дельтануудын тэнцвэр бүхий олон төлөв байдлыг ашигладаг багцын стратеги юм байна. Ред.Ч.Д.

**Е.1.10 Хейжийн хэрэглүүр: Мөнгөн алдагдалтай буцаах опцион**

**А байгууллага нь Б байгууллагын нэг хувьцаанд хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд уг хөрөнгө оруулалтыг борлуулах боломжтой гэж ангилсан. Б байгууллагын хувьцааны үнэ буурахаас хэсэгчлэн хамгаалахын тулд А байгууллага нь Б байгууллагын уг нэг хувьцааны хувьд буцаах опционыг худалдаж авсан. Түүнчлэн, Б байгууллага дахь өөрийн хувьцааны бодит үнэ цэнийн өөрчлөлтөнд хамаарах бодит үнэ цэнийн хейжийн хувьд хейжийн хэрэглүүр гэж тэрхүү буцаах опционы дотоод үнэ цэнийн өөрчлөлтийг сонгосон. Уг буцаах опцион нь Б байгууллагын нэг хувьцааг 90 ТН-ийн хэрэгжүүлэх үнээр худалдах эрхийг А байгууллагад олгодог. Хейжийн харилцаа үүсэх үед уг хувьцааны жишиг үнэ нь 100 ТН байсан. Буцаах опцион нь уг хувьцааг 90 ТН-ийн үнээр худалдах эрхийг А байгууллагад олгодог учраас тэрхүү опцион нь 90 ТН-ээс бага болох үнийн бууралтыг тухайн опционы дотоод үнэ цэнэд үндэслэн харилцан нөхөхөд ихэвчлэн бүрэн үр дүнтэй байна. 90 ТН-ээс илүү болох үнийн өөрчлөлтийн хувьд хейж хийгээгүй. Энэ тохиолдолд Б байгууллагын хувьцааны бодит үнэ цэнэ нь 90 ТН-ээс илүү болох өөрчлөлтийг УСНББОУС 29-ийн 82-р параграфын дагуу хейжийн үр дүнгүй байдал гэж үзэж, УСНББОУС 29-ийн 99-р параграфын дагуу ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх үү?**

Үгүй. Байгууллага нь опционы дотоод үнэ цэнийн өөрчлөлтийг хейжийн хэрэглүүр гэж сонгохыг УСНББОУС 29-ийн 83-р параграфтаар зөвшөөрсөн байдаг. Опционы дотоод үнэ цэнийн өөрчлөлт нь Б байгууллагын нэг хувьцааны бодит үнэ цэнэ уг опционы 90 ТН-ийн хэрэгжих үнээс бага буюу түүнтэй тэнцүү байх хувьсан өөрчлөлтийн эрсдлээс сэргийлэх хамгаалалт үүсгэдэг. Иймээс Б байгууллагын нэг хувьцааны үнэ 90ТН-ээс дээш үнэтэй болсоны олз, гарз нь хейжийн үр дүнтэй байдлыг үнэлэх ба уг хейжийн зүйлийн олз, гарзыг хүлээн зөвшөөрөх зорилгын хувьд тухайн хейж хийсэн эрсдэлд хамааралгүй юм.

Иймээс хувьцааны бодит үнэ цэнийн өөрчлөлт нь уг хувьцааны үнэ 90 ТН-ээс давж илүү гарсан хувьсан өөрчлөлттэй холбоотой (УСНББОУС 29-ийн 64-р параграф ба УСНББОУС 29-ийн 101-р параграф) бол А байгууллага нь тэрхүү өөрчлөлтийг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө. 90 ТН-ээс бага болох үнийн бууралттай холбоотой уг хувьцааны бодит үнэ цэнийн өөрчлөлт нь тухайн сонгосон бодит үнэ цэнийн хейжийн нэг хэсгийг бүрдүүлэх бөгөөд УСНББОУС 29-ийн 99(б) параграфын дагуу түүнийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Хэрэв хейжийг үр дүнтэй гэж үзвэл ашиг, алдагдалд бас хүлээн зөвшөөрдөг уг буцаах опционы дотоод үнэ цэнийн өөрчлөлтөөр тэрхүү бодит үнэ цэнийн өөрчлөлтийг харилцан нөхнө (УСНББОУС 29-ийн 99(а) параграф). Буцаах опционы цаг хугацааны үнэ цэнийн өөрчлөлтийг уг сонгосон хейжийн харилцаанд оруулахгүй бөгөөд УСНББОУС 29-ийн 65(а) параграфын дагуу ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

**Е.1.11 Хейжийн хэрэглүүр: Мөнгөн хэрэглүүрийн мөнгөн гүйлгээний хэсэг**

**Ханшийн эрсдлийн хувьд, үүсмэл бус санхүүгийн хөрөнгө буюу үүсмэл бус санхүүгийн өр төлбөр нь хейжийн хэрэглүүрийн шалгуурыг хангаж болох юм. Хейжийн хэрэглүүр гэж сонгосон санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр**



**төлбөр нь төлөгдөөгүй хэвээр байх тодорхой хугацааны туршид байгууллага нь уг мөнгөн гүйлгээг УСНББОУС 29-ийн 84-р параграфын дагуу тухайн хейжийн хэрэглүүрийн нэг хэсэг гэж үзэх ба бусад мөнгөн гүйлгээг тэрхүү сонгосон хейжийн харилцаанд оруулахгүй хасаж болох уу?**

Үгүй. Хейжийн хэрэглүүр нь эргэлтэнд байх цаг хугацааны зөвхөн тэрхүү хэсгийн хувьд хейжийн харилцааг сонгож болохгүй гэж УСНББОУС 29-ийн 84-р параграфт заасан байдаг. Жишээлбэл; гадаад валютаар илэрхийлэгдсэн, арван жилийн хугацаатай зээлийн эхний гурван жилийн хугацаанд хамаарах мөнгөн гүйлгээ нь тухайн гадаад валютаар илэрхийлэгдэх орлогын эхний гурван жилийн мөнгөн гүйлгээний хейжийн хувьд хейжийн хэрэглүүрийн шалгуурыг хангахгүй юм. Нөгөө талаас, гадаад валютаар илэрхийлэгдсэн үүсмэл бус санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр нь хейжийн хэрэглүүрийн дуусгавар болох үлдсэн хугацаатай тэнцүү буюу түүнээс урт тийм дуусгавар болох үлдсэн хугацаа бүхий хейжийн зүйлтэй холбоотой гадаад валютын эрсдлийн хейжийн хувьд хейжийн хэрэглүүрийн шалгуурыг хангаж болох юм (Асуулт Е.2.17-г үзнэ үү).

#### **Е.1.12 Нэгээс олон төрлийн эрсдлийн хейж**

**Асуудал (а) - Нийт хейжийн хэрэглүүр ба хейжийн зүйлийн хоорондох хейжийн харилцааг ихэвчлэн сонгодог бөгөөд ингэснээр тухайн хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн нэг хэмжүүртэй болдог. Энэ нь нэг санхүүгийн хэрэглүүрийг мөнгөн гүйлгээний хейж ба бодит үнэ цэнийн хейжийн аль алины хувьд хейжийн хэрэглүүр гэж нэгэн зэрэг сонгоход саад учруулах уу?**

Үгүй. Жишээлбэл; байгууллагууд нь гадаад валютаар илэрхийлэгдсэн хувьсах хүүний төлөв байдлыг бүртгэлийн валютаар илэрхийлэгдсэн тогтмол хүүний төлөв байдалд хөрвүүлэхийн тулд хүүний түвшний болон валютын хосолсон свопыг ихэвчлэн ашигладаг. Хэрэв УСНББОУС 29-ийн 85-р параграфт заасан нөхцөл хангагдаж байвал тухайн свопыг валютын эрсдлийн бодит үнэ цэнийн хейж ба хүүний түвшний эрсдлийн мөнгөн гүйлгээний хейж байдлаар тус тусад нь сонгохыг УСНББОУС 29-ийн 85-р параграфтаар зөвшөөрдөг.

**Асуудал (б) – Нэг санхүүгийн хэрэглүүр нь хоёр өөр хейжийн хувьд хейжийн хэрэглүүр байвал тусгай тодруулга хийх шаардлагатай юу?**

УСНББОУС 30-ын 25-р параграф нь тухайн сонгосон бодит үнэ цэнийн хейж, мөнгөн гүйлгээний хейж, гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хейжийн хувьд тус тусад нь тодруулга хийхийг шаарддаг. Тухайн авч хэлэлцэж буй хэрэглүүрийг УСНББОУС 30-ын 25-р параграфын дагуу хейжийн төрөл тус бүрээр тодруулж, тусад нь тайлагнана.

#### **Е.1.13 Хейжийн хэрэглүүр: Хоёр гадаад валютын форвард арилжааны гэрээ**

**А байгууллагын бүртгэлийн валют нь японы иен юм. А байгууллага нь таван жилийн хугацаатай, хөвөх хүүтэй, ам.долларын өр төлбөртэй ба арван жилийн хугацаатай, тогтмол хүүтэй, фунт стерлингээр илэрхийлэгдсэн авлагын бичигтэй байв. Уг хөрөнгө ба өр төлбөрийн үндсэн дүнг японы иенд**

**хөрвүүлэхэд ижил дүнтэй байна. А байгууллага нь хоёр хэрэглүүрийн аль алины гадаад валютын эрсдэлд хейж хийхийн тулд гадаад валютаарх нэг форвард гэрээг байгуулсан бөгөөд уг гэрээний дагуу таван жилийн эцэст ам.долларыг хүлээн авч, фунт стерлингийг төлөх юм. Хэрэв А байгууллага нь хоёр хэрэглүүрийн аль алины үндсэн дүнг буцаан төлөх үед үүсэх гадаад валютын эрсдлээс хамгаалахын тулд уг форвард арилжааны гэрээг тэрхүү мөнгөн гүйлгээний хейжид хейжийн хэрэглүүр гэж сонгосон бол энэ нь хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангах уу?**

Тийм. Хэрэв дараах гурван нөхцөл хангагдаж байвал нэг хейжийн хэрэглүүрийг олон төрлийн эрсдлийн хейж гэж сонгохыг УСНББОУС 29-ийн 85-р параграфар зөвшөөрдөг. Энэ жишээнд уг үүсмэл хейжийн хэрэглүүр нь тэдгээр бүх нөхцлүүдийг дараах байдлаар хангана:

- (a) Хейж хийсэн эрсдлүүдийг оновчтой тодорхойлж болох. Эрсдэл нь ам доллар ба иений ханшийн өөрчлөлтийн, иен ба фунт стерлингийн ханшийн өөрчлөлтийн эрсдэл тус тус байна.
- (б) Тухайн хейжийн үр дүнтэй байдлыг батлан харуулж чадах. Фунт стерлингийн зээлийн хувьд, фунт стерлингээр хийгдэх зээлийн үндсэн дүнгийн буцаан төлөлтийн бодит үнэ цэнэ ба форвард арилжааны гэрээний дагуу хийгдэх фунт стерлингийн төлбөрийн бодит үнэ цэнэ хоорондох харилцан нөхөлтийн түвшнээр үр дүнтэй байдлыг хэмжинэ. Ам долларын өр төлбөрийн хувьд, ам доллараар хийгдэх зээлийн үндсэн дүнгийн буцаан төлөлтийн бодит үнэ цэнэ ба форвард арилжааны гэрээний дагуу хийгдэх ам долларын мөнгөн орлогын бодит үнэ цэнэ хоорондох харилцан нөхөлтийн түвшнээр үр дүнтэй байдлыг хэмжинэ. Хэдийгээр авлага нь арван жилийн хугацаатай бөгөөд форвард гэрээгээр зөвхөн эхний таван жилийн хугацаанд түүнийг хамгаалдаг боловч Асуулт Е.2.17-д дурдсанчлан, эрсдлийн зөвхөн тэрхүү хэсгийн хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийг зөвшөөрдөг.
- (в) Эрсдлийн өөр өөр төлөв байдлын хувьд хейжийн хэрэглүүрийг тусгайлан сонгосон гэдгийг батлан харуулах боломжтой байх. Хейж хийсэн эрсдлийг тухайн өр төлбөр ба авлагын бичгийн илэрхийлэгдсэн тус тусын валютын хувьд үндсэн дүнгээр тодорхойлно.

**Е.1.14 Харилцан нөхөх зэрэгцээ свопууд ба тэдгээрийн нэгийг хейжийн хэрэглүүр байдлаар ашиглах**

**А байгууллага нь хүүний түвшний свопын гэрээ байгуулсан бөгөөд түүнийг тогтмол хүүтэй өрийн хэрэглүүрт хамаарах бодит үнэ цэнийн эрсдлийн хейж гэж сонгосон. Бодит үнэ цэнийн хейж нь УСНББОУС 29-д заасан хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангадаг. А байгууллага нь тухайн свопын оролцогч талтай хоёр дахь хүүний түвшний свопын гэрээг мөн нэгэн зэрэг байгуулсан бөгөөд энэ нь хүүний түвшний эхний свопыг бүрэн нөхөх нөхцөлтэй юм. А байгууллага нь хоёр свопыг нэг нэгж байдлаар үзэх ба ингэснээр эхний свопын хувьд бодит үнэ цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэхээс татгалзах шаардлагатай юу?**

Нөхцөл байдлаас хамаарна. УСНББОУС 29 нь ажил гүйлгээнд үндэслэсэн байдаг. Хоёр дахь свопын гэрээг эхний свопыг харгалзан байгуулаагүй эсвэл тухайн ажил гүйлгээг тус тусад нь зохион байгуулах бизнесийн тодорхой зорилготой бол тэдгээр свопуудыг нэг нэгж гэж үзэхгүй.

Жишээлбэл; зарим байгууллага нь хяналтанд буй байгууллагуудын хүүний түвшний эрсдэлд хейж хийхийн тулд тухайн байгууллагын хүрэн дэх хяналтанд буй бусад байгууллагуудын өмнөөс гуравдагч талтай үүсмэл хэрэглүүрийн гэрээ байгуулахыг төв төрийн сангаас (энэ нь уг эдийн засгийн байгууллагад хамаарах хяналтанд буй байгууллага юм) шаардах бодлоготой байдаг. Төрийн сан нь тухайн байгууллагын хүрээнд тэдгээр хейжийг үр дүнтэйгээр ажиллуулах нөхцлийг бүрдүүлэхийн тулд уг хяналтанд буй байгууллагуудтай дотоод үүсмэл хэрэглүүрийн ажил гүйлгээг бас хийдэг. Төрийн сан нь худалдаа арилжааны үйл ажиллагааныхаа нэг хэсэг байдлаар үүсмэл хэрэглүүрийн гэрээг бас байгуулдаг эсвэл өөрийн нийт багцын эрсдлийг дахин тэнцвэржүүлэхийн хүссэн учраас уг төрийн сан нь хяналтанд буй бусад байгууллагын өмнөөс хейжийн хэрэглүүр байдлаар байгуулсан гэрээтэй бараг ижил нөхцөл бүхий үүсмэл хэрэглүүрийн гэрээг тэрхүү гуравдагч талтай тухайн бизнесийн өдөр байгуулж болох юм. Энэ тохиолдолд уг гэрээ нэг бүрийг байгуулах бизнесийн тодорхой зорилготой гэж үзнэ.

Ажил гүйлгээг тус тусад нь зохион байгуулах бизнесийн тодорхой зорилго байгаа эсэхийг тодорхойлохын тулд шүүн тунгаалт хийдэг. Жишээлбэл; тухайн өрийн хувьд бодит үнэ цэнийн нягтлан бодох бүртгэлийн хандлагыг хэрэглэх ганцхан зорилготой бол энэ нь бизнесийн тодорхой зорилго биш гэж үзнэ.

## **E.2 Хейжийн зүйлс**

### **E.2.1 Үүсмэл хэрэглүүрийг хейжийн зүйл гэж сонгож болох эсэх**

**Үүсмэл хэрэглүүрийг (дангаар нь, буюу тусдаа хүлээн зөвшөөрсөн дагалдах үүсмэл хэрэглүүрийг) бодит үнэ цэнийн эсвэл мөнгөн гүйлгээний хейжид бие даасан байдлаар болон хейж хийсэн бүлгийн нэг хэсэг байдлаар сонгохыг, тухайлбал, хувьсах хүү төлөх ба тогтмол хүү хүлээн авах Форвард Хүүний Гэрээ (ФХГ)-г тогтмол хүү төлөх ба хувьсах хүү хүлээн авах ФХГ-ний мөнгөн гүйлгээний хейж байдлаар сонгохыг УСНББОУС 29-өөр зөвшөөрдөг үү?**

Үгүй. Үүсмэл хэрэглүүрийг үр дүнтэй хейжийн хэрэглүүр гэж сонгосноос бусад тохиолдолд үүсмэл хэрэглүүрийг ихэвчлэн худалдаа арилжааны зорилгоор эзэмших ба олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрснөөр бодит үнэ цэнээр хэмждэг гэж үздэг (УСНББОУС 29-ийн 10-р параграф). Үүнээс гажих тохиолдол болгон УСНББОУС 29-ийн МЗУ127-р параграф нь худалдан авсан опционыг бодит үнэ цэнийн хейжид хейжийн зүйл гэж сонгохыг зөвшөөрдөг.

### **E.2.2 Мөнгөн гүйлгээний хейж: Тогтмол хүүтэй өрийн урьдчилан таамагласан гаргалт**

**Тогтмол хүүтэй өрийн урьдчилан таамагласан гаргалтын хейжийн хувьд хейжийн нягтлан бодох бүртгэл хэрэглэхийг зөвшөөрдөг үү?**

Тийм. Хэрэв УСНББОУС 29-ийн 98-р параграфт заасан нөхцөл хангагдвал энэ нь ашиг, алдагдалд нөлөө үзүүлэх, өндөр магадлалтай урьдчилан таамагласан ажил гүйлгээний мөнгөн гүйлгээний хейж болно.

Үлгэрчлэн харуулвал: R байгууллага нь хугацаа дуусаж буй бондыг дахин санхүүжүүлэх, ажлын капитал бүрдүүлэх ба бусад янз бүрийн зорилгоор шинэ бондуудыг үечлэн гаргадаг. R байгууллага нь бонд гаргахаар шийдвэрлэсэн тохиолдолд тэрхүү бонд гаргахаар шийдвэрлэсэн өдрөөс тухайн бондыг гаргах өдөр хүртэлх хугацаанд урт хугацаат хүүний түвшний өөрчлөлтийн эрсдэлд хейж хийж болох юм. Хэрэв урт хугацаат хүүний түвшин өсвөл бондыг анх хүлээгдэж байснаас өндөр хүүтэй буюу өндөр хөнгөлөлттэйгээр эсвэл арай багахан урамшуулалттайгаар гаргана. Төлөх өндөр хүү эсвэл мөнгөн орлогын бууралтыг тухайн хейжийн олзоор ихэвчлэн харилцан нөхдөг. Хэрэв урт хугацаат хүүний түвшин буурвал бондыг анх хүлээгдэж байснаас бага хүүтэй буюу өндөр урамшуулалттайгаар эсвэл арай багахан хөнгөлөлттэйгээр гаргана. Төлөх бага хүү эсвэл мөнгөн орлогын өсөлтийг тухайн хейжийн гарзаар ихэвчлэн харилцан нөхдөг.

Жишээлбэл; R байгууллага нь долоон жилийн хугацаатай, 200 сая TH-ийн бондыг 2001 оны 01 дүгээр сард гаргахаар 2000 оны 8 дугаар сард шийдвэрлэсэн. R байгууллага нь түүхэн хамаарлын судалгааг хийж, түүний гаргахаар хүлээгдэж буй бондтой долоон жилийн хугацаатай, төрийн сангийн бонд зохих хамааралтай гэдгийг тодорхойлсон бөгөөд фьючерс гэрээг нэг өрийн нэгжид харьцуулсан хейжийн харьцаа нь 0.93 байна гэж үзсэн. Иймээс R байгууллага нь долоон жилийн хугацаатай, төрийн сангийн бондын хувьд 186 сая TH-ийн фьючерс гэрээг борлуулснаар (буурах төлөв байдал<sup>20</sup>) тэрхүү урьдчилан таамагласан бондын гаргалтанд хейж хийсэн. 2000 оны 8 дугаар сараас 2001 оны 01 дүгээр сар хүртэлх хугацаанд хүүний түвшин нэмэгдсэн. Уг бондыг гаргасан өдөр буюу 2001 оны 01 дүгээр сард тэрхүү фьючерсийн буурах төлөв байдлыг хаасан ба үүний үр дүнд 1.2 сая TH-ийн олз үүссэн. Уг олз нь бондын өсөн нэмэгдсэн хүүний төлбөрийг харилцан нөхөх бөгөөд иймээс тухайн бондын хугацаан дахь ашиг, алдагдалд нөлөө үзүүлнэ. Энэхүү хейж нь өрийн урьдчилан таамагласан гаргалтын хувьд хүүний түвшний эрсдлийн мөнгөн гүйлгээний хейжийн шалгуурыг хангана.

### **E.2.3 Хейжийн нягтлан бодох бүртгэл: Хадгаламжийн баазын биет бус хөрөнгө<sup>21</sup>**

**Хадгаламжийн баазын биет бус хөрөнгийн бодит үнэ цэнийн эрсдлийн хейжийн хувьд хейжийн нягтлан бодох бүртгэл хэрэглэхийг зөвшөөрдөг үү?**

<sup>20</sup> Long position-Нэмэгдэх төлөв байдал гэдэг нь хувьцаа, бараа бүтээгдэхүүн, валют гэх мэт хөрөнгийн үнэ цэнэ нэмэгдэнэ гэсэн хүлээлттэйгээр түүнийг худалдан авахыг хэлдэг. Харин short position-Буурах төлөв байдал гэдэг нь хөрөнгийн үнэ цэнэ буурна гэсэн хүлээлттэйгээр түүнийг борлуулахыг хэлнэ. Ред.Ч.Д.

<sup>21</sup> Core deposit intangibles-Хадгаламжийн баазын биет бус хөрөнгө нь банкны худалдан авалттай холбоотойгоор үүсдэг биет бус хөрөнгийн нэг хэлбэр юм. Хэдийгээр харилцах, хадгаламж нь банкны хувьд өр төлбөр боловч олон хүмүүс банкинд мөнгөө хадгалуулдаг бол тэдгээр үйлчлүүлэгчдийн бааз нь банкны үнэ цэнийг нэмэгдүүлнэ. Иймээс олон харилцагч, хадгаламж эзэмшигчтэй бол түүнийг үнэлж, банкыг худалдан авахад төлсөн нэмэлт төлбөрийг Биет бус хөрөнгө гэж үздэг байна. Ред.Ч.Д.

Энэ нь тэрхүү хадгаламжийн баазын биет бус хөрөнгийг дотооддоо бий болгосон эсвэл (жишээлбэл; улсын секторын нэгдлийн нэг хэсэг байдлаар) худалдаж авсан эсэхээс хамаардаг.

Дотооддоо бий болгосон хадгаламжийн баазын биет бус хөрөнгийг УСНББОУС 31, *Биет Бус Хөрөнгө*-ийн дагуу биет бус хөрөнгө гэж хүлээн зөвшөөрдөггүй. Ийм биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрдөггүй учраас тэдгээрийг хейжийн зүйл гэж сонгож болохгүй.

Хадгаламжийн баазын биет бус хөрөнгийг холбогдох хадгаламжийн багцын хамт худалдаж авсан бол уг хадгаламжийн баазын биет бус хөрөнгө нь УСНББОУС 31-д заасан, хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг хангах тохиолдолд түүнийг биет бус хөрөнгө (эсвэл худалдан авсан холбогдох хадгаламжийн багцын нэг хэсэг) байдлаар тусад нь хүлээн зөвшөөрөх шаардлагатай байдаг. Хүлээн зөвшөөрсөн хадгаламжийн баазын биет бус хөрөнгө нь 98-р параграфт заасан нөхцлийг, үүн дотроо хейжийн үр дүнтэй байдлыг найдвартай хэмжиж болох гэсэн 98-р параграфын шаардлагыг хангах зөвхөн тийм тохиолдолд түүнийг хейжийн зүйл гэж сонгож болно. Хадгаламжийн баазын биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үеэс бусад тохиолдолд түүний бодит үнэ цэнийг найдвартай хэмжихэд ихэвчлэн төвөгтэй байдаг учраас 98(г) параграфт заасан шаардлагыг хангах магадлал багатай юм.

#### **Е.2.4 Хейжийн нягтлан бодох бүртгэл: Гадаад валютаар илэрхийлэгдсэн ирээдүйн орлогын гүйлгээний хейж**

**Гадаад валютаар илэрхийлэгдсэн, хүлээгдэж буй боловч гэрээний бус орлогын гүйлгээнд хейж хийдэг гадаад валютын зээлийн хувьд хейжийн нягтлан бодох бүртгэл хэрэглэхийг зөвшөөрдөг үү?**

Хэрэв орлого олох магадлал өндөр бол хариулт нь тийм. УСНББОУС 29-ийн 96(б) параграфын дагуу урьдчилан таамагласан борлуулалтын хейж нь мөнгөн гүйлгээний хейж болох шалгуурыг хангаж болох юм. Жишээлбэл; хил дамнан, төлбөртэй авто замыг өмчилж, ажиллуулдаг байгууллага нь орлогоо янз бүрийн валютаар төсөвлөхийн тулд өөрийн туршлага болон эдийн засгийн мэдээнд үндэслэсэн нарийн цогц загвар ашиглаж болох юм. Ирээдүйн тодорхой хугацаанд тухайн валютаар урьдчилан таамагласан орлого нь “өндөр магадлалтай” гэдгийг байгууллага нь батлан харуулж чадах бол УСНББОУС 29-ийн 98-р параграфтаар шаардсанчлан, уг байгууллага нь тэрхүү валютын зээлийг ирээдүйн орлогын гүйлгээний мөнгөн гүйлгээний хейж гэж сонгож болно. Үр дүнтэй хейж гэж тодорхойлсон уг зээлийн олз буюу гарзын хэсгийг тэрхүү орлого үүсэх хүртэлх хугацаанд цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө.

Байгууллага нь ирээдүйн орлогыг 100 хувь найдвартайгаар урьдчилан таамаглаж чадах магадлал багатай байдаг. Нөгөө талаас, урьдчилан таамагласан орлогын тодорхой хэсэг буюу ихэвчлэн богино хугацаанд хүлээгдэж буй хэсэг нь “өндөр магадлалтай” гэсэн шалгуурыг хангадаг.

## **E.2.5 Мөнгөн гүйлгээний хейж: “Бүгдийг нэг дор” хейж**

**Тогтмол үнийн дүн бүхий төлбөрийн хариуд тухайн суурь хөрөнгийг өгснөөр үүсмэл хэрэглүүрийг нийт дүнгээр барагдуулахаар хүлээгдэж байгаа бол мөнгөн гүйлгээний хейжийн нягтлан бодох бүртгэлийн бусад шалгуур хангагдана гэж үзэх тохиолдолд уг үүсмэл хэрэглүүрийг тэрхүү нийт дүнгээр барагдуулалтын мөнгөн гүйлгээний хейжид хейжийн хэрэглүүр гэж сонгож болох уу?**

Тийм. Үүсмэл гэрээний нийт барагдуулалтаар үүсэх тухайн ирээдүйн ажил гүйлгээнд төлөх эсвэл хүлээн авах төлбөрийн хувьсан өөрчлөлтийн мөнгөн гүйлгээний хейжийн хувьд уг нийт дүнгээр барагдуулах үүсмэл хэрэглүүрийг хейжийн хэрэглүүр гэж сонгож болно. Яагаад гэвэл, тэр үүсмэл хэрэглүүр байхгүй байлаа ч гэсэн тухайн худалдан авалтын эсвэл борлуулалтын үнэ хувьсан өөрчлөгдөх эрсдэлтэй байдаг. Энэ нь УСНББОУС 29-ийн дагуу үүсмэл хэрэглүүр гэж тайлагнадаг тогтмол үнэтэй бүх гэрээнд хамаарна.

Жишээлбэл; байгууллага нь бараа бүтээгдэхүүнийг борлуулахын тулд тогтмол үнэтэй гэрээ байгуулсан бөгөөд түүнийг УСНББОУС 29-ийн дагуу үүсмэл хэрэглүүр гэж тайлагнадаг бол (тухайлбал; байгууллага нь ийм гэрээг цэвэр мөнгөөр эсвэл суурь хэрэглүүрийг нийлүүлж өгснөөр барагдуулах ба үнийн богино хугацааны хэлбэлзлээс буюу дилерийн ашиг олох зорилгоор тэрхүү нийлүүлэлтийн дараах богино хугацааны дотор түүнийг борлуулдаг практиктай тул) тогтмол үнэтэй гэрээ нь тухайн хөрөнгийг борлуулах гэрээ байлаа ч гэсэн байгууллага нь уг тогтмол үнэтэй гэрээг тэрхүү хөрөнгийн борлуулалтаар (ирээдүйн ажил гүйлгээгээр) хүлээн авах төлбөрийн хувьсан өөрчлөлтийн хувьд мөнгөн гүйлгээний хейж гэж сонгож болно. Мөн байгууллага нь бараа бүтээгдэхүүнийг нийлүүлснээр барагдуулах өрийн хэрэглүүрийг худалдан авах үүднээс форвард гэрээ байгуулсан боловч форвард гэрээний хугацаа нь зах зээлд ердийн нөхцлөөр нийлүүлэх хугацаанаас хэтэрч илүү гарах учраас тэрхүү форвард гэрээ нь үүсмэл хэрэглүүр болдог бол хэдийгээр тухайн үүсмэл хэрэглүүр нь өрийн хэрэглүүрийг олж эзэмших гэрээ байлаа ч гэсэн байгууллага нь уг өрийн хэрэглүүрийг (ирээдүйн ажил гүйлгээг) олж эзэмшихийн тулд төлөх төлбөрийн хувьсан өөрчлөлтийн хувьд мөнгөн гүйлгээний хейж байдлаар тэрхүү форвард гэрээг сонгож болох юм.

## **E.2.6 Хейжийн харилцаа: Байгууллагын хэмжээний эрсдэл**

**Байгууллага нь тэнцүү үндсэн дүн бүхий тогтмол хүүтэй хөрөнгө ба тогтмол хүүтэй өр төлбөртэй байв. Тэдгээр хэрэглүүрүүдийн нөхцлийн дагуу хөрөнгө ба өр төлбөрийн хүүний төлбөрийг нэг тайлант үед хийх бөгөөд тухайн хөрөнгийн хүүний түвшин нь өр төлбөрийн хүүний түвшнээс илүү учраас цэвэр мөнгөн гүйлгээ нь ямагт эерэг байдаг. Байгууллага нь тухайн хөрөнгийн үндсэн дүнтэй тэнцүү нэрлэсэн дүнгээс тооцож, хувьсах түвшнээр хүүг хүлээн авах ба тогтмол түвшнээр хүүг төлөх хүүний түвшний свопын гэрээг байгуулж, тэрхүү хүүний түвшний свопыг тухайн тогтмол хүүтэй хөрөнгийн бодит үнэ цэнийн хейж гэж сонгосон. Байгууллагын хэмжээнд үзүүлэх уг хүүний түвшний свопын үр нөлөө нь өмнө оршин байгаагүй хүүний түвшний өөрчлөлтийн эрсдлийг бий болгох боловч тэрхүү хейжийн харилцаа нь хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангах уу?**

Тийм. УСНББОУС 29 нь байгууллагын хэмжээний эрсдлийн бууралтыг хейжийн нягтлан бодох бүртгэлийн нэг нөхцөл гэж шаарддаггүй. Эрсдлийг ажил гүйлгээнд үндэслэн үнэлэх бөгөөд энэ жишээний хувьд, хейж хийж буй хөрөнгө нь хүүний түвшний өсөлтөөс хамаарах бодит үнэ цэнийн эрсдэлтэй байх бөгөөд үүнийг уг хүүний түвшний свопоор харилцан нөхнө.

**Е.2.7 Мөнгөн гүйлгээний хейж: Байгууллагын цэвэр хөрөнгө/өмчтэй холбоотой урьдчилан таамагласан ажил гүйлгээ**

**Байгууллагын өөрийн өмчийн хэрэглүүрийн урьдчилан таамагласан ажил гүйлгээ буюу эздэд олгох урьдчилан таамагласан ногдол ашиг болон адилтгах төлбөрүүдийг мөнгөн гүйлгээний хейжийн хувьд хейжийн зүйл гэж сонгож болох уу?**

Үгүй. Хейжийн зүйл болох шалгуурыг хангахын тулд урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь ашиг, алдагдалд нөлөө үзүүлэх тодорхой эрсдэлд тухайн байгууллагыг өртүүлдэг байх ёстой (УСНББОУС 29-ийн 96-р параграф). Санхүүгийн хэрэглүүрийг өр төлбөр эсвэл цэвэр хөрөнгө/өмч гэж ангилах ангилал нь тухайн ажил гүйлгээ болон ийм хэрэглүүртэй холбоотой бусад төлбөрүүдийг УСНББОУС 28-ын дагуу ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх эсэхийг тодорхойлох суурь үндэслэл болдог. Жишээлбэл; гаргагч нь тухайн өмчийн хэрэглүүрийн эзэмшигчдэд олгох хуваарилалтыг цэвэр хөрөнгө/өмчид шууд дебитлэдэг (УСНББОУС 28-ын 40-р параграф). Ийм учраас ийм хуваарилалтыг хейжийн зүйл гэж сонгож болохгүй. Гэвч хараахан төлөөгүй ба санхүүгийн өр төлбөр гэж хүлээн зөвшөөрдөг, зарласан ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт нь тухайлбал, гадаад валютаар илэрхийлэгдсэн бол гадаад валютын эрсдлийн хувьд хейжийн зүйл болох шалгуурыг хангаж болох юм.

**Е.2.8 Хейжийн нягтлан бодох бүртгэл: Гарч тохиолдоогүй байгаа ажил гүйлгээний эрсдэл**

**Ажил гүйлгээ гарч тохиолдохгүй байх, жишээлбэл тухайн байгууллагын хүлээж байснаас бага хэмжээний орлого олох эрсдлийн хейжийн хувьд байгууллага нь хейжийн нягтлан бодох бүртгэл хэрэглэхийг УСНББОУС 29-өөр зөвшөөрдөг үү?**

Үгүй. Ажил гүйлгээ гарч тохиолдохгүй байх эрсдэл нь хейжийн зүйл болох шалгуурыг хангахгүй, үйл ажиллагааны ерөнхий эрсдэл юм. Зөвхөн хүлээн зөвшөөрсөн хөрөнгө ба өр төлбөр, арилжааны баталгаа, өндөр магадлалтай урьдчилан таамагласан ажил гүйлгээ, гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийг зөвшөөрдөг (УСНББОУС 29-ийн 96-р параграф).

**Е.2.9 Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт: Хувьсах хүүний төлбөрийн хейж**

**Хувьсах хүү-төлөх ба тогтмол хүү-хүлээн авах хүүний түвшний свопыг байгууллага нь хувьсах хүүтэй, дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын хувьд мөнгөн гүйлгээний хейж гэж сонгож болох уу?**

Үгүй. Свопыг өрийн хөрөнгө оруулалтын хувьсах хүүний төлбөрүүдийн мөнгөн гүйлгээний хейж гэж сонгох ангилал нь өрийн хөрөнгө оруулалтыг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших гэж ангилах ангилалтай нийцэхгүй. “Хөрөнгө оруулалтыг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших гэж ангилах нь хүүний түвшний өөрчлөлтийн улмаас уг хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ буюу мөнгөн гүйлгээнд гарах өөрчлөлтөөс үл хамааран тухайн хөрөнгө оруулалтыг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших санаа зорилготой байхыг шаарддаг” тул ийм дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт нь хүүний түвшний эрсдэл болон урьдчилан төлөх эрсдлийн хувьд хейжийн зүйл болж чадахгүй гэж УСНББОУС 29-ийн 88-р параграфт заасан.

**Е.2.10 Хейжийн зүйл: Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтын худалдан авалт**

Урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдох тэр үед дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших гэж ангилах санаа зорилготой байгаа тийм санхүүгийн хөрөнгийн худалдан авалтыг уг байгууллага нь урьдчилан таамаглаж байна. Тус байгууллага нь одоогийн хүүний түвшнийг тогтвортой байлгах зорилгоор үүсмэл хэрэглүүрийн гэрээ байгуулсан бөгөөд тэрхүү үүсмэл хэрэглүүрийг тухайн санхүүгийн хөрөнгийн урьдчилан таамагласан худалдан авалтын хейж гэж сонгосон. Тухайн хөрөнгийг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт гэж ангилсан ч гэсэн уг хейжийн харилцаа нь мөнгөн гүйлгээний хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангах уу?

Тийм. Хүүний түвшний эрсдлийн хувьд, УСНББОУС 29 нь дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших гэж ангилсан санхүүгийн хөрөнгөнд хейжийн нягтлан бодох бүртгэл хэрэглэхийг хориглодог (УСНББОУС 29-ийн 88-р параграф). Хэдийгээр байгууллага нь тухайн хөрөнгийг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших гэж ангилах санаа зорилготой байлаа ч гэсэн уг ажил гүйлгээ гарч тохиолдох хүртэл тэрхүү хэрэглүүрийг ингэж ангилахгүй.

**Е.2.11 Мөнгөн гүйлгээний хейж: Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтаас олж авсан мөнгө сангаар дахин хөрөнгө оруулалт хийх**

Байгууллага нь дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших гэж ангилсан хувьсах хүүтэй хөрөнгийг өмчилдөг. Тус байгууллага нь хувьсах хүүний мөнгөн гүйлгээгээр хийх дахин хөрөнгө оруулалтын хувьд одоогийн хүүний түвшинг хэвээр хадгалах санаа зорилготойгоор үүсмэл хэрэглүүрийн гэрээг байгуулсан бөгөөд дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтанд уг хүүний орлогоор дахин хөрөнгө оруулалт хийсний үр дүн болох тухайн өрийн хэрэглүүрийн ирээдүйн урьдчилан таамагласан хүүний орлогын мөнгөн гүйлгээний хейж гэж тэрхүү үүсмэл хэрэглүүрийг сонгосон. Хейжийн нягтлан бодох бүртгэлийн бусад шалгуур хангагдана гэж үзвэл тэрхүү дахин хөрөнгө оруулж буй хүүний төлбөрүүд нь дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших гэж ангилсан тэрхүү хөрөнгөөс үүсэх боловч уг хейжийн харилцаа нь мөнгөн гүйлгээний хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангах уу?



Тийм. Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт нь хүүний түвшний эрсдлийн хувьд хейжийн зүйл байж болохгүй гэж УСНББОУС 29-ийн 88-р параграфт заасан. Энэ нь зөвхөн бодит үнэ цэнийн хейжид, өөрөөр хэлбэл тогтмол хүү төлдөг, дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалттай холбоотой бодит үнэ цэнийн хүүний түвшний эрсдлийн хейжид төдийгүй мөнгөн гүйлгээний хейжид, өөрөөр хэлбэл, одоогийн зах зээлийн түвшнээр хувьсах хүү төлдөг, дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалттай холбоотой мөнгөн гүйлгээний хүүний түвшний эрсдлийн хейжид бас хамаарна гэдгийг Асуулт E.2.8-д тусгайлан заасан. Гэвч энэ жишээнд, дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалтанд тэрхүү хувьсах хүүний мөнгөн орлогоор дахин хөрөнгө оруулалт хийсний үр дүн болох уг өрийн хэрэглүүрийн ирээдүйн урьдчилан таамагласан хүүний орлогын хувьд тухайн үүсмэл хэрэглүүрийг мөнгөн гүйлгээний эрсдлийн нөхөлт байдлаар сонгосон. Дахин хөрөнгө оруулалт хийхээр урьдчилан таамагласан мөнгө сангийн эх үүсвэр нь уг дахин хөрөнгө оруулалтын эрсдэлд хейж хийж болох эсэхийг тодорхойлоход хамааралгүй юм. Иймээс уг үүсмэл хэрэглүүрийг мөнгөн гүйлгээний хейж гэж сонгохыг зөвшөөрнө. Дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших гэж ангилсан, тогтмол хүүтэй хөрөнгөнд уг хүүний орлогоор дахин хөрөнгө оруулалт хийсний үр дүн болох тухайн өрийн хэрэглүүрийн ирээдүйн урьдчилан таамагласан хүүний орлоготой холбоотой мөнгөн гүйлгээний эрсдлийн хейжид энэхүү хариулт бас хамаарна.

#### **E.2.12 Хейжийн нягтлан бодох бүртгэл: Урьдчилан төлж болох санхүүгийн хөрөнгө**

**Гаргагч нь санхүүгийн хөрөнгийг урьдчилан төлөх эрхтэй бол хөрөнгө оруулагч нь уг урьдчилсан төлбөрийн өдрийн дараах мөнгөн гүйлгээг тухайн хейжийн зүйлийн нэг хэсэг гэж сонгож болох уу?**

Урьдчилсан төлбөрийн өдрийн дараах мөнгөн гүйлгээ нь “өндөр магадлалтай” гэдгийг батлан харуулж чадах тохиолдолд түүнийг хейжийн зүйл гэж сонгож болно (УСНББОУС 29-ийн 98-р параграф). Тухайлбал; урьдчилсан төлбөрийн өдрийн дараах мөнгөн гүйлгээ нь түүний урьдчилсан төлбөрийг нарийн оновчтойгоор тооцоолж чадах ижил төсөөтэй хөрөнгүүдийн бүлэг буюу нэгдлийн (жишээлбэл; моргейжийн зээл) үр дүн бол, эсвэл урьдчилан төлөх сонголт нь мэдэгдэхүйц мөнгөн алдагдалтай бол тэдгээр мөнгөн гүйлгээ нь өндөр магадлалтай гэсэн шалгуурыг хангаж болох юм. Түүнчлэн, уг хейжийн хэрэглүүрийн хувьд адилтгах сонголт байгаа бол тэрхүү урьдчилсан төлбөрийн өдрийн дараах мөнгөн гүйлгээг хейжийн зүйл гэж сонгож болно.

#### **E.2.13 Бодит үнэ цэнийн хейж: Ашиг, алдагдалд нөлөөлж болох эрсдэл**

**Зээл ба авлага гэж ангилсан, тогтмол хүүтэй зээлийн хүүний түвшний эрсдлийн хувьд бодит үнэ цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэл хэрэглэхийг зөвшөөрдөг үү?**

Тийм. УСНББОУС 29-ийн дагуу зээл ба авлагыг хорогдуулсан өртгөөр бүртгэдэг. Олон байгууллага нь зээл ба авлагын багцыг тэдгээрийн дуусгавар болох хугацаа хүртэл эзэмшдэг. Иймээс зах зээлийн хүүний түвшний өөрчлөлтөөс хамааран ийм

зээл ба авлагын бодит үнэ цэнэд гарсан өөрчлөлт нь ашиг, алдагдалд нөлөө үзүүлдэггүй. Бодит үнэ цэнийн хейж гэдэг нь тодорхой эрсдэлд хамааруул болох бөгөөд ашиг, алдагдалд нөлөө үзүүлэх тийм бодит үнэ цэнийн өөрчлөлтийн хейж гэж УСНББОУС 29-ийн 96-р параграфт тусгайлан заасан байдаг. Иймээс УСНББОУС 29-ийн 96-р параграф нь зээл ба авлагын хувьд бодит үнэ цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэл хэрэглэхийг хориглодог гэж харагдаж болох юм. Гэвч зээл ба авлагыг дуусгавар болох хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт гэж ангилдаггүй учраас хүүний түвшний эрсдлийн хувьд зээл ба авлага нь хейжийн зүйл байж болно гэж УСНББОУС 29-ийн 88-р параграфтаас дүгнэж болно. Байгууллага нь ийм хөрөнгийг худалдан борлуулж болох бөгөөд тэдгээрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдалд нөлөөлнө. Иймээс зээл ба авлагын хувьд бодит үнэ цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэл хэрэглэхийг зөвшөөрдөг.

#### **Е.2.14 Групп доторх болон байгууллага доторх хейжийн ажил гүйлгээ**

**Бүртгэлийн валют нь Австрали улсын доллар байх Австралийн байгууллага нь японы иенээр хийгдэх өндөр магадлалтай, урьдчилан таамагласан худалдан авалттай байв. Уг Австралийн байгууллагыг Швейцарийн байгууллага нь бүрэн өмчилдөг бөгөөд өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайланг (үүн дотроо, тэрхүү Австралийн охин компанийг тусган оруулдаг) швейцарийн франкаар бэлтгэдэг. Уг хяналт тавигч Швейцарийн байгууллага нь Австрали доллартай харьцах иений өөрчлөлтөнд хейж хийхийн тулд форвард гэрээ байгуулсан. Ийм хейж нь тухайн нэгтгэсэн санхүүгийн тайланд хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангах уу, эсвэл гадаад валютын эрсдэл бүхий тэрхүү хяналтанд буй Австралийн байгууллага нь уг хейжийн ажил гүйлгээний оролцогч тал болох ёстой юу?**

УСНББОУС 29-д заасан хейжийн нягтлан бодох бүртгэлийн бусад шалгуур хангагдах бол тэрхүү хейж нь хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангана. Уг Австралийн байгууллага нь иенээр хийгдэх тэрхүү урьдчилан таамагласан худалдан авалттай холбоотой гадаад валютын ханшийн эрсдэлд хейж хийдэггүй учраас Австрали доллар ба иений хоорондох ханшийн өөрчлөлтийн үр нөлөө нь Австралийн байгууллагын ашиг, алдагдалд нөлөөлөх ба иймээс нэгтгэсэн ашиг, алдагдалд мөн нөлөө үзүүлнэ. Хейж хийж буй эрсдэлд өртөх тухайн үйл ажиллагааны нэгж нь тэрхүү хейжийн хэрэглүүрийн оролцогч тал байхыг УСНББОУС 29-өөр шаарддаггүй.

#### **Е.2.15 Дотоод гэрээ: Харилцан нөхөх гаднын нэг үүсмэл хэрэглүүр**

**Байгууллага нь хүүний түвшний эрсдлийн хариуцлагыг бие даасан хэлтсээс төв төрийн санд шилжүүлсэн гэдгийг баримтжуулахын тулд дотоод үүсмэл хэрэглүүрийн гэрээ гэж нэрлэгдэх хэрэглүүрийг ашигладаг. Төв төрийн сан нь дотоод үүсмэл гэрээнүүдийг нэгтгэн нийлүүлж, тэдгээр дотоод үүсмэл гэрээг цэвэр дүнгээр харилцан нөхөх гаднын нэг үүсмэл гэрээг байгуулдаг. Жишээлбэл; бусад хэлтсүүдийн хувьсах хүүтэй өр төлбөрийн хувьсах хүүний мөнгөн гүйлгээний эрсдэлд өртдөг, тогтмол хүү хүлээн авах ба хувьсах хүү төлөх хүүний түвшний дотоод гурван свопын гэрээ болон өөр нэг хэлтсийн хувьсах хүүтэй хөрөнгийн хувьсах хүүний мөнгөн гүйлгээний эрсдэлд өртдөг, хувьсах хүү хүлээн авах ба тогтмол хүү төлөх дотоод нэг**

**свопын гэрээг төрийн сан нь байгуулсан бол уг төрийн сан нь тэдгээр дөрвөн дотоод свопыг яг харилцан нөхөх хүүний түвшний свопын гэрээг гаднын байгууллагатай байгуулна. Хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангагдсан гэж үзвэл тэрхүү харилцан нөхөх гаднын нэг үүсмэл хэрэглүүр нь нийт дүнгээрээ тэдгээр суурь зүйлсийн нэг хэсэг болох хейжийн хувьд тухайн байгууллагын санхүүгийн тайланд хейжийн хэрэглүүрийн шалгуурыг хангах уу?**

Тэрхүү гаднын үүсмэл хэрэглүүрийг нийт дүнгээр нь, мөнгөн орлогын гүйлгээ эсвэл мөнгөн зарлагын гүйлгээнд харилцан нөхөлт гэж сонгосон зөвхөн тийм тохиолдолд хариулт нь тийм байна. Ерөнхий цэвэр төлөв байдлын хейж нь хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангахгүй гэж УСНББОУС 29-ийн 94-р параграфт заасан байдаг. Гэвч суурь зүйлсийн нэг хэсгийг нийт дүнгээр нь, хейж хийсэн төлөв байдал гэж сонгохыг энэхүү Стандартаар зөвшөөрдөг. Иймээс гаднын үүсмэл гэрээг байгуулах зорилго нь дотоод үүсмэл гэрээнүүдийг цэвэр дүнгээр харилцан нөхөх явдал боловч тухайн хейжийн харилцааг тэдгээр суурь мөнгөн орлогын гүйлгээний эсвэл мөнгөн зарлагын гүйлгээний хейж гэж нийт дүнгээр нь тодорхойлж, баримтжуулсан бол хейжийн нягтлан бодох бүртгэл хэрэглэхийг зөвшөөрдөг. Суурь мөнгөн гүйлгээний нэг хэсгийг хейж хийсэн төлөв байдал гэж сонгохын тулд байгууллага нь УСНББОУС 29-ийн 94-р параграф болон УСНББОУС 29-ийн МЗУ141-р параграфт дурдсан хандлагыг баримтална.

#### **Е.2.16 Дотоод гэрээ: Цэвэр дүнгээр барагдуулах гаднын үүсмэл гэрээ**

**Асуудал (а) – Байгууллага нь хүүний түвшний эрсдлийг бие даасан хэлтсээс төв төрийн санд шилжүүлэхийн тулд дотоод үүсмэл гэрээг ашигладаг. Дотоод үүсмэл гэрээ тус бүрийн хувьд, төв төрийн сан нь уг дотоод үүсмэл гэрээг харилцан нөхөх үүсмэл хэрэглүүрийн гэрээг гаднын нэг байгууллагатай байгуулдаг. Жишээлбэл; ЛАЙБОР хүү төлөх зээлийн хувьд хүүний мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлтийн эрсдэлд хейж хийхийн тулд төв төрийн сантай дотоод үүсмэл гэрээ байгуулсан нэг хэлтэстэй уг төрийн сан нь 5 хувийн тогтмол хүү авах ба ЛАЙБОР хүү төлөх хүүний түвшний свопын гэрээ байгуулсан бол тэрхүү төв төрийн сан нь ижилхэн үндсэн нөхцөлтэй, 5 хувийн тогтмол хүү төлөх ба ЛАЙБОР хүү хүлээн авах хүүний түвшний свопын гэрээг гаднын оролцогч талтай байгуулах юм. Гаднын үүсмэл гэрээ нэг бүрийг тусдаа гэрээ байдлаар албан ёсоор баримтжуулдаг боловч тухайн гаднын оролцогч талтай цэвэр дүнгээр барагдуулах гэрээтэй учраас гаднын бүх үүсмэл гэрээний төлбөрүүдийг зөвхөн цэвэр дүнгээр дүнгээр барагдуулна. Хейжийн нягтлан бодох бүртгэлийн бусад шалгуур хангагдана гэж үзвэл, дээр дурдсан 5 хувийн тогтмол хүү төлөх ба ЛАЙБОР хүү хүлээн авах хүүний түвшний своп гэх мэт бие даасан гаднын үүсмэл гэрээнүүдийг хэдийгээр цэвэр дүнгээр барагдуулдаг боловч дээрх ЛАЙБОР хүү төлөх зээлийн хувьд хувьсах хүүний төлбөрийн өөрчлөлтийн эрсдэл зэрэг суурь нийт эрсдлийн хейжийн хэрэглүүр гэж сонгож болох уу?**

Ерөнхийдөө тийм. Хэрэв УСНББОУС 29-д заасан, хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуур хангагдвал гаднын гэрээнүүдийг тухайн гаднын талтай цэвэр дүнгээр барагдуулдаг боловч эрх зүйн хувьд тусдаа гэрээ бөгөөд эрсдлийг нийт дүнгээр шилжүүлэх гэх мэт бизнесийн тодорхой зорилгод үйлчилдэг, гаднын

үүсмэл гэрээ нь хейжийн хэрэглүүрийн шалгуурыг хангадаг. Асуулт Е.1.13-ыг үзнэ үү.

**Асуудал (б) – Харилцан нөхөх гаднын гэрээнүүдийг байгуулж, төвлөрсөн багцад тэдгээрийг оруулснаар төрийн сан нь тухайн эрсдлийг цаашид цэвэр дүнгээр үнэлж чадахгүй гэж үзсэн. Төрийн сан нь харилцан нөхөх гаднын үүсмэл хэрэглүүрүүдийн багцыг тухайн байгууллагын бусад эрсдлээс тусад нь удирдан зохицуулахыг хүсэж байна. Иймээс төрийн сан нь уг багцын эрсдлийг харилцан нөхөх нэмэлт нэг үүсмэл гэрээг байгуулсан. Уг гаднын гэрээнүүдийг байгуулсанаар үүсэх зах зээлийн эрсдлийг бүрэн нөхөхийн тулд нэг гаднын үүсмэл гэрээг ашигладаг байсан боловч тухайн багц дахь бие даасан гаднын үүсмэл гэрээнүүдийг тэрхүү суурь нийт эрсдлийн хувьд хейжийн хэрэглүүр гэж сонгосон хэвээр байж болох уу?**

Ерөнхийдөө тийм. Гаднын үүсмэл гэрээг ийм маягаар хийх зорилго нь тухайн байгууллагын эрсдлийн удирдлагын зорилтууд ба стратегитай нийцдэг. Дээр дурдсанчлан, эрх зүйн хувьд тусдаа гэрээ бөгөөд бизнесийн тодорхой зорилгод үйлчилдэг, гаднын үүсмэл гэрээ нь хейжийн хэрэглүүрийн шалгуурыг хангадаг. Түүнчлэн, байгууллага нь тухайн ажил гүйлгээг зохион байгуулах тодорхой зорилго байгаа бол уг оролцогч талтай байгуулсан өөр свопын гэрээний нөхцөлтэй яг ижил свопын гэрээг байгуулах учраас хейжийн нягтлан бодох бүртгэлийг шууд хориглохгүй гэдгийг Асуулт Е.1.13-ын хариултанд тусгайлан заасан.

#### **Е.2.17 Хэсэгчилсэн хугацааны хейж**

**Хейжийн хэрэглүүр эргэлтэнд байх үед хейжийн харилцааг зөвхөн түүний цаг хугацаанд хамаарах хэсгийн хувьд сонгож болохгүй гэж УСНББОУС 29-ийн 84-р параграфт заасан. Харин хейжийн зүйлийн дуусгавар болох хугацаа хүртэлх цаг хугацааны тэрхүү хэсгийн хувьд үүсмэл хэрэглүүрийг хейж гэж сонгохыг зөвшөөрдөг үү?**

Тийм. Үр дүнтэй байдлыг нь хэмжиж болох ба хейжийн нягтлан бодох бүртгэлийн бусад шалгуур хангагдаж байвал санхүүгийн хэрэглүүр нь түүний мөнгөн гүйлгээний буюу бодит үнэ цэнийн зөвхөн тодорхой хэсгийн хувьд хейжийн зүйл байж болно.

Үлгэрчлэн харуулвал: А байгууллага нь 10 хувийн тогтмол хүүтэй, дуусгавар болох хугацаа хүртэл арван жилийн үлдсэн хугацаатай засгийн газрын бондыг худалдан авчээ. А байгууллага нь уг бондыг борлуулах боломжтой гэж ангилдаг. 5 дахь жил хүртэлх хүүний төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнэтэй холбоотойгоор уг бондод үүсэх бодит үнэ цэнийн эрсдлийн хувьд хейж хийхийн тулд А байгууллага нь таван жилийн хугацаатай, тогтмол хүү төлөх ба хөвөх хүү хүлээн авах свопыг олж эзэмшсэн. 5 жилийн хугацаатай свопод хамаарах өгөөжийн муруйн өөрчлөлт нь тухайн засгийн газрын бондын 5 дахь жил хүртэлх хүүний төлбөрүүдийн бодит үнэ цэнэд болон дуусгавар болох үед төлөх ёстой үндсэн дүнгийн үнэ цэнэд нөлөө үзүүлдэг тохиолдолд тэдгээрийн эрсдлийн хувьд уг свопыг хейжийн хэрэглүүр гэж сонгож болох юм.

**Е.2.18 Хейжийн хэрэглүүр: Валют хоорондох хүүний түвшний своп**

**А байгууллагын бүртгэлийн валют нь японы иен юм. А байгууллага нь таван жилийн хугацаатай, хөвөх хүүтэй, ам.долларын өр төлбөртэй ба арван жилийн хугацаатай, тогтмол хүүтэй, фунт стерлингээр илэрхийлэгдсэн авлагын бичигтэй байв. А байгууллага нь хөрөнгө, өр төлбөрийн гадаад валютын эрсдэлд болон авлагын бичгийн хүүний түвшний бодит үнэ цэнийн эрсдэлд хейж хийхийг хүссэн бөгөөд хөвөх хүүтэйгээр ам доллар хүлээн авах, тогтмол хүүтэйгээр фунт стерлинг төлөх ба таван жилийн эцэст уг ам долларыг фунт стерлингээр солих харилцан уялдсан валют хоорондын хүүний түвшний свопын гэрээг байгуулсан. А байгууллагын хувьд ам доллар ба фунт стерлинг нь хоёулаа гадаад валют боловч А байгууллага нь гадаад валютын эрсдэл болон хүүний түвшний эрсдлийн аль алины хувьд бодит үнэ цэнийн хейжид уг свопыг хейжийн хэрэглүүр гэж сонгож болох уу?**

Тийм. Үр дүнтэй байдлыг нь хэмжиж чадах бол эрсдлийн бүрэлдэхүүн хэсгийн хувьд хейжийн нягтлан бодох бүртгэл хэрэглэхийг УСНББОУС 29-ийн 90-р параграфтаар зөвшөөрдөг. Эрсдлүүдийг оновчтой тодорхойлж, хейжийн үр дүнтэй байдлыг харуулж чадах ба эрсдлийн өөр өөр төлөв байдлын хувьд хейжийн хэрэглүүрийг тусгайлан сонгосон гэдгийг батлан харуулах боломжтой бол нэг хейжийн хэрэглүүрийг нэгээс олон төрлийн эрсдлийн хувьд хейж гэж сонгохыг УСНББОУС 29-ийн 85-р параграфтаар зөвшөөрсөн байдаг. Иймээс авлагын бичгийн эхний таван жилийн хэсэгчилсэн хугацаанд Их Британи дахь хүүний түвшний өөрчлөлт, түүнчлэн фунт стерлинг ба ам долларын ханшийн зөрүүтэй холбоотойгоор түүний бодит үнэ цэнэ өөрчлөгдөх эрсдлээс хамгаалахын тулд бодит үнэ цэнийн хейжид уг свопыг хейжийн хэрэглүүр гэж сонгож болно. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрснөөр уг свопыг бодит үнэ цэнээр хэмжинэ. Өгөөжийн муруйн эхний таван жилийн хугацаанд Их Британид хүүний түвшин өөрчлөгдсөний улмаас авлагын бодит үнэ цэнэд гарсан өөрчлөлтийн хувьд түүний дансны үнийг тохируулна. Авлага, өглөгийг УСНББОУС 4-ийн дагуу спот ханш ашиглан дахин хэмжих бөгөөд тэдгээрийн дансны үнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

**Е.2.19 Хейжийн зүйл: Нийтэд арилждаг хувьцааны гадаад валютын эрсдлийн хейж**

**А байгууллага нь Б байгууллагын хувьцааг түүни 1,000 гадаад валют (ГВ)-ын бодит үнэ цэнээр гадаадын хөрөнгийн бирж дээрээс худалдаж авсан. А байгууллага нь уг хувьцааг борлуулах боломжтой гэж ангилсан. Тэрхүү хувьцаатай холбоотой гадаад валютын ханшийн өөрчлөлтийн эрсдлээс өөрийгөө хамгаалахын тулд тус байгууллага нь уг хувьцааг 750 ГВ-аар худалдах форвард гэрээг байгуулжээ. А байгууллага нь хувьцааг хадгалж байх үедээ тэрхүү форвард арилжааны гэрээг эзэмшсэн хэвээр байх санаа зорилготой байна. Хейжийн нягтлан бодох бүртгэлийн бусад шалгуур хангагдана гэж үзвэл уг форвард арилжааны гэрээ нь хувьцаатай холбоотой гадаад валютын ханшийн эрсдлийн хувьд хейж болох шалгуурыг хангаж чадах уу?**

Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн илт ойлгомжтой ба тодорхойлж болох эрсдэлтэй зөвхөн тийм тохиолдолд хариулт нь тийм байна. Иймээс хэрэв (а) А байгууллагын бүртгэлийн валюттай ижил валютаар арилжаа нь илэрхийлэгддэг хөрөнгийн биржид (эсвэл тогтсон бусад зах зээлд) уг өмчийн хэрэглүүрийг арилждаггүй, (б) А байгууллагад олгох ногдол ашгийг тухайн валютаар илэрхийлдэггүй бол хейжийн нягтлан бодох бүртгэл хэрэглэхийг зөвшөөрнө. Ийм учраас хувьцааг олон янзын валютаар арилждаг бөгөөд тэдгээр валютын аль нэг нь тухайн тайлагнагч байгууллагын бүртгэлийн валют бол уг хувьцааны үнийн гадаад валютын бүрэлдэхүүн хэсгийн хувьд хейжийн нягтлан бодох бүртгэл хэрэглэхийг зөвшөөрөхгүй.

**Хэрэв тийм бол, тухайн хувьцааны бодит үнэ цэнийн 750 ГВ хүртэлх хэсэгтэй холбоотой гадаад валютын ханшийн эрсдлийн хейжийн хувьд уг форвард арилжааны гэрээг хейжийн хэрэглүүр гэж сонгож болох уу?**

Тийм. Хэрэв үр дүнтэй байдлыг нь хэмжиж чадах бол санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээний эсвэл бодит үнэ цэнийн хэсгийг хейжийн зүйл гэж сонгохыг УСНББОУС 29-өөр зөвшөөрсөн байдаг (УСНББОУС 29-ийн 90-р параграф). Иймээс А байгууллага нь хувьцааны бодит үнэ цэнийн зөвхөн гадаад валютаарх хэсэгтэй холбоотой гадаад валютын ханшийн эрсдлийн хейж гэж уг форвард арилжааны гэрээг сонгож болно. Үүнийг тухайн хувьцаатай холбоотой 750 ГВ-ын хувьд гадаад валютын ханшийн эрсдлийн бодит үнэ цэнийн хейж, эсвэл тэрхүү хувьцааг борлуулах хугацааг тогтоосон бол хувьцааны урьдчилан таамагласан борлуулалтын мөнгөн гүйлгээний хейж гэж сонгож болох юм. Хувьцааны гадаад валютаарх бодит үнэ цэнэ нь 750 ГВ-аас бага байхаас бусад тохиолдолд уг хувьцааны гадаад валютаарх бодит үнэ цэнийн аливаа хувьсан өөрчлөлт нь хейжийн үр дүнтэй байдлын үнэлгээнд нөлөө үзүүлэхгүй.

#### **Е.2.20 Хейжийн нягтлан бодох бүртгэл: Хувьцааны индекс**

**Байгууллага нь хувьцааны индексийг тусган илэрхийлэхийн тулд багц хувьцааг, түүнчлэн бодит үнэ цэнийн гарзаас өөрийгөө хамгаалах үүднээс тэрхүү индексэд үндэслэсэн буцаах опционыг олж эзэмшиж болох юм. Хувьцааны индексд үндэслэсэн буцаах опционыг тэрхүү багц хувьцааны хейжийн хувьд хейжийн хэрэглүүр гэж сонгохыг УСНББОУС 29-өөр зөвшөөрдөг үү?**

Үгүй. Хэрэв ижил төсөөтэй санхүүгийн хэрэглүүрүүдийг нэгтгэн нийлүүлж, бүлэг байдлаар хейж хийдэг бол уг бүлэг дэх бие даасан зүйл тус бүрийн хувьд хейж хийсэн эрсдэлтэй холбоотой бодит үнэ цэнийн өөрчлөлт нь тухайн бүлгийн хувьд хейж хийсэн эрсдэлтэй холбоотой бодит үнэ цэнийн нийт өөрчлөлттэй ойролцоогоор шууд хамааралтай байна гэж үздэг болохыг УСНББОУС 29-ийн 93-р параграфт заасан. Дээр дурдсан тохиолдолд, тухайн бүлэг дэх бие даасан зүйл тус бүрийн (хувьцааны бие даасан үнүүд) хувьд хейж хийсэн эрсдэлтэй холбоотой бодит үнэ цэнийн өөрчлөлт нь тэрхүү бүлгийн хувьд хейж хийсэн эрсдэлтэй холбоотой бодит үнэ цэнийн нийт өөрчлөлттэй ойролцоогоор шууд хамааралтай гэж үзэхээргүй байна.

**Е.2.21 Хейжийн нягтлан бодох бүртгэл: Хөрөнгө ба өр төлбөрийг харилцан суутгаж, цэвэр дүн гаргах**

**Хейжийн нягтлан бодох бүртгэлийн зорилгоор байгууллага нь хейж хийх уг цэвэр мөнгөн гүйлгээний эрсдлийг тодорхойлохын тулд санхүүгийн хөрөнгийг санхүүгийн өр төлбөрийн хамт бүлэглэж болох уу?**

Байгууллагын хейжийн стратеги ба эрсдлийн удирдлагын практикын дагуу мөнгөн гүйлгээний эрсдлийг цэвэр дүнгээр үнэлдэг байж болох боловч УСНББОУС 29-ийн 94-р параграф нь хейжийн нягтлан бодох бүртгэлийн зорилгоор цэвэр мөнгөн гүйлгээний эрсдлийг хейжийн зүйл гэж сонгохыг зөвшөөрдөггүй. Байгууллага нь өөрийн эрсдлийг хэрхэн цэвэр дүнгээр (ижил төсөөтэй хөрөнгө ба өр төлбөрийг хамтад нь бүлэглэснээр) үнэлэх ба үүний дараа, нийт дүнгээр хейж хийснээр хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангаж болох талаархи жишээг УСНББОУС 29-ийн МЗУ141-р параграфт харуулсан.

**Е.3 Хейжийн нягтлан бодох бүртгэл**

**Е.3.1 Мөнгөн гүйлгээний хейж: Тогтмол хүүтэй мөнгөн гүйлгээ**

**Байгууллага нь тогтмол хүүтэй өрийн хэрэглүүрийг гаргасан бөгөөд уг өрийн хэрэглүүртэй холбоотой хүүний түвшний эрсдлийг харилцан нөхөхийн тулд тогтмол хүү хүлээн авах ба хувьсах хүү төлөх хүүний түвшний свопын гэрээ байгуулсан. Байгууллага нь тухайн өрийн хэрэглүүртэй холбоотой ирээдүйн хүүний мөнгөн зарлагын гүйлгээний хувьд уг свопыг мөнгөн гүйлгээний хейж гэж сонгож болох уу?**

Үгүй. Мөнгөн гүйлгээний хейж нь “мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлтийн эрсдлийн хейж” гэж УСНББОУС 29-ийн 96(б) параграфт заасан. Энэ тохиолдолд хүүний төлбөр тогтмол учраас уг гаргасан өрийн хэрэглүүр нь мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлтийн ямар нэг эрсдэл үүсгэхгүй. Байгууллага нь уг свопыг тэрхүү өрийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хейж гэж сонгож болох боловч өрийн хэрэглүүрийн ирээдүйн мөнгөн зарлагын гүйлгээний хувьд мөнгөн гүйлгээний хейж гэж сонгож болохгүй.

**Е.3.2 Мөнгөн гүйлгээний хейж: Тогтмол хүүтэй мөнгөн гүйлгээгээр дахин хөрөнгө оруулалт хийх**

**Байгууллага нь хүүний түвшний эрсдлийг цэвэр дүнгээр удирдан зохицуулдаг. 2002 оны 1-р улиралд тогтмол хүүтэй хөрөнгийн нийт мөнгөн орлогын гүйлгээ 100 ТН, тогтмол хүүтэй өр төлбөрийн нийт мөнгөн зарлагын гүйлгээ 90 ТН болно гэж уг байгууллага нь 2001 оны 01 дүгээр сарын 01-нд урьдчилан таамагласан. Эрсдэлийн удирдлагын зорилгоор тус байгууллага нь уг урьдчилан таамагласан 10 ТН-ийн цэвэр мөнгөн орлогын гүйлгээнд хейж хийхийн тулд хувьсах хүү хүлээн авах ба тогтмол хүү төлөх Форвард Хүүний Гэрээ (ФХГ) байгуулсан. Тус байгууллага нь 2002 оны 1-р улиралд тогтмол хүүтэй хөрөнгөөс олох эхний 10 ТН-ийн мөнгөн орлогын гүйлгээг хейжийн зүйл гэж сонгосон. Байгууллага нь уг тогтмол хүүтэй хөрөнгөтэй холбоотой 2002 оны 1-р улирлын мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлтийн**

**эрсдлийн хувьд тэрхүү хувьсах хүү авах ба тогтмол хүү төлөх ФХГ-г мөнгөн гүйлгээний хейж гэж сонгож болох уу?**

Үгүй. ФХГ нь мөнгөн гүйлгээний эрсдэлгүй учраас тогтмол хүүтэй хөрөнгөтэй холбоотой мөнгөн гүйлгээний хувьд мөнгөн гүйлгээний хейжийн шалгуурыг хангахгүй. Гэвч байгууллага нь тухайн мөнгөн гүйлгээ шилжигдэхээс өмнө оршин байсан бодит үнэ цэнийн эрсдлийн хувьд уг ФХГ-г хейжийн хэрэглүүр гэж сонгож болно.

Зарим тохиолдолд, байгууллага нь уг тогтмол хүүтэй хөрөнгөөс хүлээн авах хүү болон үндсэн дүнгээр хийх урьдчилан таамагласан дахин хөрөнгө оруулалттай хүүний түвшний эрсдэлд мөн хейж хийж болох юм (Асуулт Е.6.2-ыг үзнэ үү). Гэвч, энэ жишээнд ФХГ нь хүүний мөнгөн гүйлгээгээр дахин хөрөнгө оруулалт хийснээр хүүний мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлтийг бууруулахгүй, харин нэмэгдүүлэх учраас мөнгөн гүйлгээний хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангахгүй (жишээлбэл; хэрэв зах зээлийн хүү өсвөл уг ФХГ-ээс мөнгөн орлогын гүйлгээ үүсэх бөгөөд тогтмол хүүтэй хөрөнгийн хүүний мөнгөн орлогын гүйлгээгээр хийх дахин хөрөнгө оруулалтын үр дүнд үүсэхээр хүлээгдэж буй хүүний мөнгөн орлогын гүйлгээ нэмэгдэх болно). Харин уг гэрээ нь нийт дүнгээр хийгдэх мөнгөн зарлагын гүйлгээний дахин санхүүжилтийн хэсгийн хувьд мөнгөн гүйлгээний хейжийн шалгуурыг хангаж болох юм.

**Е.3.3 Гадаад валютын хейж**

**А байгууллага нь зургаан сарын дараа төлөх гадаад валютын өр төлбөртэй бөгөөд барагдуулалтын үеийн гадаад валютын ханшийн хэлбэлзэлийн хувьд хейж хийхийг хүссэн. Үүний тулд уг байгууллага нь зургаан сарын дараа гадаад валют худалдан авах форвард гэрээ байгуулжээ. Ийм хейжийг дараах хейжийн аль нь гэж үзэх вэ?**

- (a) **Өр төлбөр ба форвард гэрээний аль алинд тухайн жилийн эцэст ханшийн тэгшитгэл хийснээр үүсэх олз, гарзыг нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх уг өр төлбөрийн бодит үнэ цэнийн хейж; эсвэл**
- (б) **Форвард гэрээнд ханшийн тэгшитгэл хийснээр үүсэх олз, гарзыг нь цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрснөөр ирээдүйд барагдуулах дүнгийн мөнгөн гүйлгээний хейж.**

УСНББОУС 29 нь энэ хоёр аргын аль алиныг хориглодоггүй. Хэрэв уг хейжийг бодит үнэ цэнийн хейж гэж үзвэл тухайн хейж хийсэн эрсдлийн хувьд хейжийн хэрэглүүрийг бодит үнэ цэнээр дахин хэмжилтийн олз, гарз болон хейжийн зүйлийг бодит үнэ цэнээр дахин хэмжилтийн олз, гарзыг нь ашиг, алдагдалд нэн даруй хүлээн зөвшөөрнө. Форвард гэрээг дахин хэмжсэнээр үүсэх олз, гарзыг нь цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрч, уг хейжийг мөнгөн гүйлгээний хейж гэж үзвэл тухайн хейжийн зүйл (өр төлбөр) нь ашиг, алдагдалд нөлөө үзүүлэх, өөрөөр хэлбэл гадаад валютын ханшийн өөрчлөлтийн хувьд өр төлбөрийг дахин хэмждэг тайлант үе буюу үеүдэд тэрхүү дүнг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Иймээс хэрэв хейж нь үр дүнтэй бол төлбөр төлсөн үед биш, харин өр төлбөрийг дахин хэмжсэн тэрхүү



тайлант үеүдэд тухайн үүсмэл хэрэглүүрийн олз, гарзыг нь ашиг, алдагдалд тусгана. Асуулт Е.3.4-ийг үзнэ үү.

#### **Е.3.4 Гадаад валютын мөнгөн гүйлгээний хейж**

**Байгууллага нь гадаад валютаар илэрхийлэгдсэн үнээр бүтээгдэхүүнийг экспортолдог. Борлуулалтын өдөр уг байгууллага нь тэрхүү борлуулалтын үнийн хувьд 90 хоногийн дараа төлөгдөх авлагатай болсон бөгөөд авлагын гадаад валютын хэлбэлзэлд хейж хийхийн тулд түүнтэй ижил валютаар илэрхийлэгдсэн 90 хоногийн хугацаатай форвард арилжааны гэрээг байгуулсан.**

**Үүний дагуу, борлуулалтыг тухайн борлуулалт хийсэн өдрийн спот ханшаар бүртгэх ба 90 хоногийн турш дахь ханшийн өөрчлөлтийн хувьд авлагад тэгшитгэл хийж, зөрүүг нь ашиг, алдагдалд тусгадаг (УСНББОУС 4-ийн 27-р параграф ба УСНББОУС 4-ийн 32-р параграф).**

**Хэрэв уг гадаад валютын арилжааны гэрээг хейжийн хэрэглүүр гэж сонгосон бол байгууллага нь тухайн гадаад валютын арилжааны гэрээг авлагын гадаад валютын эрсдлийн хувьд бодит үнэ цэнийн хейж эсвэл авлагын цуглуулалтын хувьд мөнгөн гүйлгээний хейж гэж үзэх эсэх сонголттой байх уу?**

Тийм. Хэрэв байгууллага нь гадаад валютын арилжааны гэрээг бодит үнэ цэнийн хейж гэж сонгосон бол тэрхүү форвард арилжааны гэрээг бодит үнэ цэнээр дахин хэмжсэнээс үүссэн олз, гарзыг ашиг, алдагдалд нэн даруй хүлээн зөвшөөрөх ба авлагын дахин хэмжилтээс үүссэн олз, гарзыг мөн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Хэрэв байгууллага нь гадаад валютын арилжааны гэрээг тухайн авлагын цуглуулалттай холбоотой гадаад валютын эрсдлийн хувьд мөнгөн гүйлгээний хейж гэж сонгосон бол үр дүнтэй хейж гэж сонгосон тэрхүү олз, гарзын хэсгийг цэвэр хөрөнгө/өмчид, харин үр дүнтэй бус хэсгийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө (УСНББОУС 29-ийн 106-р параграф). Цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн дүнг уг авлагын хэмжилтийн өөрчлөлт нь ашиг, алдагдалд нөлөөлөх тухайн тайлант үед буюу үеүдэд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө (УСНББОУС 29-ийн 111-р параграф).

#### **Е.3.5 Бодит үнэ цэнийн хейж: Хувьсах хүүтэй өрийн хэрэглүүр**

**Байгууллага нь хувьсах хүүтэй өрийн хэрэглүүрийн эрсдлийн тодорхой хэсгийг бодит үнэ цэнийн хейжид хейжийн зүйл гэж сонгохыг УСНББОУС 29-өөр зөвшөөрдөг үү?**

Тийм. Хувьсах хүүтэй өрийн хэрэглүүр нь зээлийн эрсдлийн улмаас бодит үнэ цэнийн өөрчлөлтийн эрсдэлд өртөж болох юм. Уг өрийн хэрэглүүрийн хувьсан хүүний түвшинг дахин тогтоох хугацаа хооронд зах зээлийн хүүний түвшинд гарсан өөрчлөлттэй холбоотойгоор түүний бодит үнэ цэнэ өөрчлөгдөх эрсдэлд бас өртөж болно. Жишээлбэл; өрийн хэрэглүүр нь зах зээлийн хүүнийн түвшнээр жил тутам тогтоогдох хүүний төлбөрүүдтэй бол уг өрийн хэрэглүүрийн тодорхой хэсэг нь

тухайн жилийн туршид бодит үнэ цэнийн өөрчлөлттэй холбоотойгоор эрсдэлд өртдөг.

### **Е.3.6 Бодит үнэ цэнийн хейж: Бараа материал**

**Бодит үнэ цэнийн хейж нь “хүлээн зөвшөөрсөн хөрөнгө буюу өр төлбөрийн эсвэл ... бодит үнэ цэнэд гарах бөгөөд тодорхой эрсдэлд хамааруулж болох, түүнчлэн ашиг, алдагдалд нөлөө үзүүлэх өөрчлөлтүүдийн хувьд хийгдэх хейж” гэж УСНББОУС 29-ийн 96(a) параграфт заасан. Бараа материалыг УСНББОУС 12, *Бараа материал*-ын дагуу өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн, эсвэл өртөг ба одоогийн орлуулалтын өртгийн аль багаар хэмждэг боловч байгууллага нь газрын тос зэрэг бараа материалыг уг газрын тосны үнэ гэх мэт бараа материалын үнийн өөрчлөлтийн эрсдлийн хувьд бодит үнэ цэнийн хейжид хейжийн зүйл гэж сонгож болох уу?**

Тийм. Бараа материалыг борлуулах эсвэл түүний дансны үнийг бууруулах үед бараа материалын бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдалд нөлөөлдөг учраас зэсийн үнийн өөрчлөлтөөс шалтгаалсан бодит үнэ цэнийн өөрчлөлтийн хувьд тухайн бараа материалд хейж хийж болно. УСНББОУС 12-ын дагуу өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль бага зарчмыг мөрдөх зорилгын хувьд уг тохируулсан дансны үнэ нь өртгийн суурь болно. Бараа материалын бодит үнэ цэнийн хейжид ашигласан хейжийн хэрэглүүр нь мөн бараа материалын ирээдүйн борлуулалтын хувьд мөнгөн гүйлгээний хейжийн шалгуурыг хангаж болох юм.

### **Е.3.7 Хейжийн нягтлан бодох бүртгэл: Урьдчилан таамагласан ажил гүйлгээ**

**Мөнгөн гүйлгээний хейжийн хувьд, уг хейжийн зүйл болох урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь “өндөр магадлалтай” байх ёстой. “Өндөр магадлалтай” гэсэн нэр томъёог хэрхэн тайлбарлах вэ?**

“Өндөр магадлалтай” нэр томъёо нь “гарч тохиолдохгүй байх илүү магадлалтай” гэсэн нэр томъёоноос гарч тохиолдох илүү их магадлалтай гэдгийг илэрхийлнэ. Урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдох магадлалын үнэлгээ нь зөвхөн удирдлагын санаа зорилгод үндэслэхгүй, яагаад гэвэл уг санаа зорилгыг шалгах боломжгүй байдаг. Ажил гүйлгээний магадлалыг ажиглаж болох баримт материал болон тухайн оролцогчийн нөхцөл байдлаар дэмжин баталгаажуулсан байвал зохино.

Ажил гүйлгээ гарч тохиолдох магадлалыг үнэлэхдээ, байгууллага нь дараах нөхцөл байдлуудыг харгалзан үзнэ:

- (a) Өнгөрсөн хугацааны ижил төсөөтэй ажил гүйлгээний давтамж;
- (b) Ажил гүйлгээг гүйцэтгэх уг байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны чадвар боломж;
- (b) Тухайн тодорхой үйл ажиллагаанд (жишээлбэл; тусгай дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх) зориулан нөөцийг олгох томоохон баталгаа;

- (г) Хэрэв ажил гүйлгээ гарч тохиолдохгүй бол үүсэж болох гарзын хэмжээ эсвэл үйл ажиллагааны тасалдалт;
- (д) Тухайн нэг зорилгод хүрэхийн тулд эрс өөр шинж чанар бүхий ажил гүйлгээг ашиглаж болох магадлал (жишээлбэл; мөнгө босгох санаа зорилготой байгаа байгууллага нь банкны богино хугацаат зээл авахаас эхлээд өрийн хэрэглүүрийг санал болгох гэх мэт хэд хэдэн арга замуудтай байж болох юм); ба
- (е) Тухайн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө.

Урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдох хүртэлх тооцоолсон хугацааны урт нь мөн магадлалыг тодорхойлох хүчин зүйл юм. Бусад хүчин зүйлс хэвээр байх үед уг урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдох хүртэлх хугацаа урт байх тусам тухайн ажил гүйлгээг гарч тохиолдох өндөр магадлалтай гэж үзэх магадлал буурдаг бөгөөд өндөр магадлалтай гэсэн батламж мэдэгдлийг дэмжих илүү хүчтэй нотолгоо шаардлагатай байдаг.

Жишээлбэл; таван жилийн дараа гарч тохиолдоно гэж урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь нэг жилийн дараа гарч тохиолдоно гэж урьдчилан таамагласан ажил гүйлгээнээс гарч тохиолдох магадлал багатай байж болох юм. Гэвч хүчин төгөлдөр гэрээний үүргээр дэмжигдэн батлагдсан бол хувьсах хүүтэй өрийн хувьд дараагийн 20 жилийн хугацаанд төлөх урьдчилан таамагласан хүүний төлбөрүүд нь ихэвчлэн өндөр магадлалтай байдаг.

Түүнчлэн, бусад хүчин зүйлс хэвээр байх үед тухайн байгууллагын ижил шинж төрөлтэй ажил гүйлгээнүүдтэй харьцуулахад биет тоо хэмжээ буюу ирээдүйн үнэ цэнийн хувьд их хэмжээтэй ажил гүйлгээг өндөр магадлалтай ажил гүйлгээ гэж үзэх магадлал бага байдаг бөгөөд өндөр магадлалтай гэсэн батламж мэдэгдлийг дэмжих илүү хүчтэй нотолгоо шаардлагатай болдог. Жишээлбэл; сүүлийн гурван сарын хугацаанд сарын борлуулалт нь дундажаар 950,000 нэгж байх тохиолдолд дараагийн сарын борлуулалт 950,000 нэгж гэхийн оронд 100,000 нэгжийн борлуулалт хийж чадна гэсэн урьдчилсан таамаглалыг дэмжихэд ерөнхийдөө арай бага нотолгоо шаардагдах юм.

Урьдчилан таамагласан ажил гүйлгээний хувьд хейжийг сонгосон ба дараа нь уг урьдчилан таамагласан ажил гүйлгээ цаашид гарч тохиолдохооргүй боллоо гэж тодорхойлж байсан түүх нь ажил гүйлгээг үнэн зөв урьдчилан таамаглах уг байгууллагын чадвар боломж ба урьдчилан таамагласан ижил төсөөтэй ажил гүйлгээнд ирээдүйд хейжийн нягтлан бодох бүртгэлийг ашиглах тохиромжтой байдлын аль алины хувьд эргэлзээ төрүүлэх юм.

### **Е.3.8 Хейжийг буцаан сонгох**

#### **Байгууллага нь хейжийн харилцааг буцаан сонгохыг УСНББОУС 29-өөр зөвшөөрдөг үү?**

Үгүй. Хейжийн харилцааны сонголт нь УСНББОУС 29-ийн 98-р параграфт заасан хейжийн нягтлан бодох бүртгэлийн бүх шалгуур хангагдсан өдрөөс эхлэн ирээдүйд үйлчилдэг. Тухайлбал; байгууллага нь хейжийн харилцааны шаардлагатай бүх баримтжуулалтыг, үүн дотроо хейжийн хэрэглүүр, холбогдох хейжийн зүйл буюу

ажил гүйлгээ, хейж хийж буй эрсдлийн шинж төрөл, хейжийн үр дүнтэй байдлыг байгууллага хэрхэн үнэлэх тодорхойлолтыг бүрэн бүрдүүлсэн өдрөөс зөвхөн эхлэн хейжийн нягтлан бодох бүртгэлийг мөрдөж болно.

### **Е.3.9 Хейжийн нягтлан бодох бүртгэл: Хейжийг эхэн дэх сонголт**

**Байгууллага нь үүсмэл хэрэглүүрийн гэрээг байгуулсаны дараа уг үүсмэл гэрээг хейжийн хэрэглүүр гэж сонгож, албан ёсоор баримтжуулахыг УСНББОУС 29-өөр зөвшөөрдөг үү?**

Хэтийн ирээдүйд хариулт нь тийм. Хейжийн нягтлан бодох бүртгэлийн хувьд, УСНББОУС 29 нь тухайн хейжийн харилцаа эхэлсэн өдрөөс эхлэн хейжийн хэрэглүүрийг сонгож, ийм байдлаар албан ёсоор баримтжуулахыг шаарддаг (УСНББОУС 29-ийн 98-р параграф); өөрөөр хэлбэл, хейжийн харилцааг буцаан сонгож болохгүй. Мөн Стандарт нь хейжийн хэрэглүүр эргэлтэнд байх үед хейжийн харилцааг зөвхөн түүний цаг хугацаанд хамаарах хэсгийн хувьд сонгохыг хориглодог (УСНББОУС 29-ийн 84-р параграф). Гэвч энэ Стандарт нь хейжийн хэрэглүүрийг тухайн хейжийн харилцааны эхэнд олж эзэмшихийг шаарддаггүй.

### **Е.3.10 Хейжийн нягтлан бодох бүртгэл: Хейж хийсэн, урьдчилан таамагласан ажил гүйлгээг тодорхойлох**

**Урьдчилан таамагласан ажил гүйлгээг тусгайлан заасан хугацаан дахь бүтээгдэхүүний сүүлийн 15,000 нэгжийн худалдан авалт буюу борлуулалт гэж, эсвэл тусгайлан заасан хугацааны турш дахь худалдан авалт буюу борлуулалтын хувийн жингээр тодорхойлж болох уу?**

Үгүй. Хейж хийсэн, урьдчилан таамагласан ажил гүйлгээг хангалттай ойлгомжтой тодорхойлж, баримтжуулах ёстой, ингэснээр уг ажил гүйлгээ гарч тохиолдох үед энэ нь хейж хийсэн ажил гүйлгээ мөн, эсвэл биш гэдэг нь тодорхой байх ёстой. Иймээс урьдчилан таамагласан ажил гүйлгээг уг тусгайлан заасан гурван сарын хугацаан дахь тэрхүү бүтээгдэхүүний эхний 15,000 нэгжийн борлуулалт гэж тодорхойлж болно, харин сүүлийн 15,000 нэгжийг хэзээ борлуулахыг тодорхойлж чадахгүй учраас гурван сарын хугацаанд борлуулах бүтээгдэхүүний сүүлийн 15,000 нэгж гэж тодорхойлж болохгүй. Үүнтэй адил шалтгаанаар уг урьдчилан таамагласан ажил гүйлгээг тодорхой хугацааны турш дахь худалдан авалт эсвэл борлуулалтын зөвхөн хувийн жин байдлаар тодорхойлж болохгүй.

### **Е.3.11 Мөнгөн гүйлгээний хейж: Урьдчилан таамагласан ажил гүйлгээний хугацааны баримтжуулалт**

**Урьдчилан таамагласан ажил гүйлгээний хейжийн хувьд, тухайн хейжийн эхэнд тогтоосон хейжийн харилцааны баримтжуулалт нь тэрхүү урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдохоор хүлээгдэж буй өдөр буюу хугацааг тодорхойлох хэрэгтэй юу?**

Тийм. Хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангахын тулд уг хейж нь тусгайлан тодорхойлсон ба сонгосон эрсдэлтэй холбоотой байх ёстой (УСНББОУС 29-ийн МЗУ151-р параграф) бөгөөд түүний үр дүнтэй байдлыг найдвартай хэмжих боломжтой байх ёстой (УСНББОУС 29-ийн 98(г) параграф). Мөн хейж хийсэн

урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь өндөр магадлалтай байх ёстой (УСНББОУС 29-ийн 98(в) параграф). Эдгээр шалгуурыг хангахын тулд урьдчилан таамагласан ажил гүйлгээний гарч тохиолдохоор хүлээгдэж яг тодорхой өдрийг таамаглаж, баримтжуулахыг байгууллагаас шаарддаггүй. Гэвч хейжийн үр дүнтэй байдлыг үнэлэх суурь үндэслэл болгон хамгийн их магадлалтай өдрөөс эхлэн уг урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдохоор хүлээгдэж буй ул үндэслэлтэй тодорхой бөгөөд ерөнхийдөө өргөн бус хугацааны муж доторх үеийг тодорхойлж, баримтжуулахыг тухайн байгууллагаас шаардана. Хейж нь УСНББОУС 29-ийн 98(г) параграфын дагуу өндөр үр дүнтэй эсэхийг тодорхойлохын тулд хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөр уг хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний бодит үнэ цэнийн өөрчлөлтийг харилцан нөхнө гэдгийг ханган магадлах шаардлагатай бөгөөд тэдгээр мөнгөн гүйлгээнүүдийн хугацаа нь бие биетэйгээ ойролцоо байх зөвхөн тийм тохиолдолд энэхүү шалгуур хангагдаж болох юм. Урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь цаашид гарч тохиолдохоор хүлээгдэхээ болисон бол УСНББОУС 29-ийн 112(в) параграфын хейжийн нягтлан бодох бүртгэлийг зогсооно.

#### **E.4 Хейжийн үр дүнтэй байдал**

##### **E.4.1 Татварын дараах дүнгээр хейж хийх**

**Хейжийг ихэвчлэн татварын дараах дүнгээр хийдэг. Хейжийн үр дүнтэй байдлыг татварын дараах дүнгээр үнэлэх үү?**

УСНББОУС 29 нь хейжийн үр дүнтэй байдлыг татварын дараах дүнгээр үнэлэхийг зөвшөөрдөг боловч заавал шаарддаггүй. Хэрэв хейжийг татварын дараах дүнгээр хийдэг бол хейжийн харилцаа болон стратегийн албан ёсны баримтжуулалтын нэгэн хэсэг болгон хейжийг эхнээс нь ингэж сонгоно.

##### **E.4.2 Хейжийн үр дүнтэй байдал: Хуримтлагдсан дүнгээр үнэлэх**

**Хейж нь өндөр үр дүнтэй гэж хүлээгдэж байхыг УСНББОУС 29-ийн 98(а) параграфтаар шаарддаг. Хүлээгдэж буй хейжийн үр дүнтэй байдлыг тайлант үе бүрээр тусад нь, эсвэл тухайн хейжийн харилцааны нийт хугацааны туршид хуримтлагдсан дүнгээр үнэлэх үү?**

Хейжийг хуримтлагдсан дүнгээр сонгосон ба тэрхүү нөхцлийг хейжийн зохих баримтжуулалтанд тусгасан бол уг хүлээгдэж буй хейжийн үр дүнтэй байдлыг хуримтлагдсан дүнгээр үнэлж болно. Иймээс хейж нь тодорхой нэг тайлант үед өндөр үр дүнтэй байхаар хүлээгдээгүй боловч уг хейжийн харилцааны нийт хугацааны туршид хангалттай өндөр үр дүнтэй хэвээр байхаар хүлээгдэж байвал хейжийн нягтлан бодох бүртгэлийг хориглохгүй. Гэхдээ аливаа үр дүнгүй байдлыг гарч тохиолдсон үед нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх шаардлагатай юм.

Үлгэрчлэн харуулвал: байгууллага нь Их Британийн суурь хүүний түвшин дээр ашгийн түвшинг нэмсэн хүү бүхий зээлийн хейж болгон ЛАЙБОР-т үндэслэсэн хүүний түвшний свопыг сонгосон. Их Британийн суурь хүүний түвшин нь магадгүй улиралд буюу түүнээс богино хугацаанд нэг удаа 25-50 суурь оноогоор өөрчлөгддөг бол ЛАЙБОР нь өдөр бүр өөрчлөгддөг. Уг хейж нь 1-2 жилийн хугацаанд бараг төгс тохиромжтой гэж хүлээгдэж байв. Гэвч Их Британийн суурь хүүний түвшин зарим

улиралд огт өөрчлөгддөггүй бол ЛАЙБОР хүү нь эрс өөрчлөгддөг. Энэ нь хейжийн нягтлан бодох бүртгэлийг хориглох зайлшгүй нөхцөл болж чадахгүй.

#### **Е.4.3 Хейжийн үр дүнтэй байдал: Оролцогч нөгөө талын зээлийн эрсдэл**

**Хейжийн үр дүнтэй байдлыг үнэлэхдээ байгууллага нь тухайн хейжийн хэрэглүүрийн оролцогч нөгөө тал үүргээ биелүүлэхгүй байх магадлалыг харгалзан үзэх ёстой юу?**

Тийм. Байгууллага нь уг хейжийн хэрэглүүрийн гэрээний нөхцлийн дагуу авах ёстой бүх дүнгээ цуглуулж чадах эсэхээ харгалзахгүй орхиж болохгүй. Хейжийн эхэнд болон явцад түүний үр дүнтэй байдлыг үнэлэх үедээ байгууллага нь тухайн хейжийн хэрэглүүрийн оролцогч нөгөө тал түүнд гэрээний дагуу аливаа төлбөрийг хийхгүй байснаар үүргээ биелүүлэхгүй байх эрсдлийг харгалзах үзнэ. Мөнгөн гүйлгээний хейжийн хувьд, оролцогч нөгөө тал нь үүргээ биелүүлэхгүй байх нилээд магадлалтай байвал байгууллага нь мөнгөн гүйлгээний харилцан нөхөлтөнд хүрэхэд тэрхүү хейжийн харилцаа өндөр үр дүнтэй байхаар хүлээгдэж байна гэж дүгнэх боломжгүй юм. Иймээс хейжийн нягтлан бодох бүртгэлийг зогсооно. Бодит үнэ цэнийн хейжийн хувьд, хэрэв оролцогч нөгөө талын зээлийн үнэлэмж өөрчлөгдвөл уг хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ нь өөрчлөгдөх бөгөөд ингэснээр тухайн хейжийн харилцааг үр дүнтэй эсэх болон хейжийн нягтлан бодох бүртгэлийг үргэлжлүүлэх шалгуур хангагдаж буй эсэх үнэлгээнд нөлөө үзүүлнэ.

#### **Е.4.4 Хейжийн үр дүнтэй байдал: Үр дүнтэй байдлын сорил**

**Хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг анх хангах ба үргэлжлүүлэн хангах зорилгын хувьд хейжийн үр дүнтэй байдлыг хэрхэн хэмжих вэ?**

УСНББОУС 29 нь үр дүнтэй байдлын сорилыг хэрхэн гүйцэтгэх талаархи тодорхой заавар удирдамжаар хангадаггүй. Зөвхөн дараах тохиолдолд хейжийг үндсэндээ өндөр үр дүнтэй гэж үзнэ гэдгийг УСНББОУС 29-д заасан: (а) Хейжийн эхэнд болон дараагийн тайлант үеүдэд уг хейж нь түүнийг сонгосон тайлант үеийн туршид тухайн хейж хийсэн эрсдэлд хамааруулах бодит үнэ цэнийн буюу мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг нөхөхөд өндөр үр дүнтэй байхаар хүлээгдэж байх, ба (б) Хейжийн бодит үр дүн нь 80-125 хувь гэсэн муж дотор байх. Мөн (а)-д заасан хүлээлтийш янз бүрийн арга замаар батлан харуулж болно гэдгийг УСНББОУС 29-ийн МЗУ145-р параграфт заасан.

Хейжийн үр дүнтэй байдлыг үнэлэх тухайн аргын тохиромжтой байдал нь хейж хийж буй эрсдлийн шинж төрөл ба ашигласан хейжийн хэрэглүүрийн төрлөөс хамаарна. Өөр бусад арга тохиромжтой гэдгийг илт батлан харуулахаас бусад тохиолдолд үр дүнтэй байдлыг үнэлэх тухайн арга нь ул үндэслэлтэй бөгөөд ижил төсөөтэй бусад хейжтэй нийцсэн байх ёстой. Байгууллага нь үр дүнтэй байдлыг хэрхэн үнэлэхийг тухайн хейжийн эхэнд баримтжуулах бөгөөд хейжийн хугацааны туршид тэрхүү үр дүнтэй байдлын сорилыг тууштайгаар хэрэглэх ёстой.

Хейжийн үр дүнтэй байдлыг хэмжихийн тулд математикийн хэд хэдэн арга зүйг ашиглаж болно. Үүнд: харьцааны шинжилгээ, өөрөөр хэлбэл хугацааны тодорхой агшин дахь хейжийн олз, гарзыг уг хейжийн зүйлийн харгалзах олз, гарзтай

харьцуулах, мөн регрессийн шинжилгээ гэх мэт статистик хэмжилтийн арга зүй хамаарна. Хэрэв регрессийн шинжилгээг ашигладаг бол үр дүнтэй байдлыг үнэлэх уг байгууллагын баримтжуулсан бодлого нь регрессийн шинжилгээний үр дүнг хэрхэн үнэлэх талаар тусгайлан заасан байх ёстой.

**Е.4.5 Хейжийн үр дүнтэй байдал: 100 хувиас бага хэмжээний харилцан нөхөлт**

**Бодит эрсдлийн нөхөлт нь бүрэн нөхөлтийн хэлбэлзлийн зөвшөөрөгдсөн 80-125 хувийн муж дотор байгаа учраас мөнгөн гүйлгээний хейжийг өндөр үр дүнтэй гэж үзсэн бол тэрхүү хейжийн үр дүнгүй хэсгийн олз, гарзыг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрөх үү?**

Үгүй. Хейжийн зөвхөн үр дүнтэй хэсгийг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө гэж УСНББОУС 29-ийн 106(а) параграфт заасан. УСНББОУС 29-ийн 106(б) параграф нь үр дүнгүй хэсгийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөхийг шаарддаг.

**Е.4.6 Хейжийн төгс үр дүнтэй байдал гэж үзэх**

**Хейжийн хэрэглүүр ба уг хейж хийсэн нийт хөрөнгө буюу өр төлбөр, эсвэл хейж хийсэн урьдчилан таамагласан ажил гүйлгээний үндсэн нөхцлүүд ижил бол байгууллага нь үр дүнтэй байдлыг цаашид сорьж шалгахгүйгээр хейжийн төгс үр дүнтэй байдал байна гэж үзэж болох уу?**

Үгүй. Байгууллага нь хейжийн үр дүнтэй байдлын хувьд хейжийг тасралтгүй сууриар үнэлэхийг УСНББОУС 29-ийн 98(д) параграфтаар шаарддаг. Хэрэглүүрийн хөрвөх чадвар буюу түүний зээлийн эрсдэл гэх мэт бусад шинжүүдийн улмаас хейжийн үр дүнгүй байдал үүсэж болох учраас тухайн хейжийн хэрэглүүр ба хейжийн зүйлийн үндсэн нөхцлүүд ижил боловч хейж үр дүнтэй гэж үзэж болохгүй юм (УСНББОУС 29-ийн МЗУ150-р параграф). Гэвч байгууллага нь ерөнхий эрсдэл өртөлтийн хувьд зөвхөн зарим эрсдэлд хейж хийсэн гэж сонгож, ингэснээр тухайн хейжийн харилцааны үр дүнтэй байдлыг сайжруулж болох юм. Жишээлбэл; өрийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хейжийн хувьд, үүсмэл хейжийн хэрэглүүр нь АА-үнэлгээтэй адилтгах зээлийн эрсдэлтэй бол байгууллага нь зөвхөн АА-үнэлгээтэй хүүний түвшний өөрчлөлттэй холбоотой эрсдлийн хувьд хейж хийсэн гэж сонгож болох ба ийм тохиолдолд зээлийн тархалтын өөрчлөлт нь хейжийн үр дүнтэй байдалд нөлөөлөхгүй.

**Е.5 Мөнгөн гүйлгээний хейж**

**Е.5.1 Хейжийн нягтлан бодох бүртгэл: Хейжийн хэрэглүүр болгон ашигласан үүсмэл бус мөнгөн зүйлсийн хөрөнгө буюу үүсмэл бус мөнгөн зүйлсийн өр төлбөр**

**Байгууллага нь үүсмэл бус мөнгөн зүйлсийн өр төлбөрийн үндсэн дүнгийн буцаан төлөлтийн хувьд гадаад валютын мөнгөн гүйлгээний хейж гэж үүсмэл бус мөнгөн зүйлсийн хөрөнгийг сонгодог бол уг хейжийн зүйлийн ханшийн зөрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх (УСНББОУС 4-ийн 32-р параграф) ба хейжийн хэрэглүүрийн ханшийн зөрүүг тухайн өр төлбөрийг буцаан төлөх**

**хүртэл цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрөх үү (УСНББОУС 29-ийн 106-р параграф)?**

Үгүй. Мөнгөн зүйлсийн хөрөнгө ба мөнгөн зүйлсийн өр төлбөрийн аль алины ханшийн зөрүүг тэдгээрийн үүссэн тайлант үед ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө (УСНББОУС 4-ийн 32-р параграф). Хэрэв үүсмэл бус мөнгөн зүйлсийн хөрөнгө ба үүсмэл бус мөнгөн зүйлсийн өр төлбөрийн хооронд хейжийн харилцаа байгаа бол тэдгээр санхүүгийн хэрэглүүийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө гэж УСНББОУС 29-ийн МЗУ116-р параграфт тусгайлан заасан байдаг.

**Е.5.2 Мөнгөн гүйлгээний хейж: Хейжийн хэрэглүүрийн гүйцэтгэл (1)**

**А байгууллага нь дуусгавар болох хүртэл таван жилийн үлдсэн хугацаатай, хөвөх хүүтэй, 1,000 ТН-ийн өр төлбөртэй байв. Байгууллага нь хүүний түвшний эрсдэлд хамааруулж болох хөвөх хүүтэй өр төлбөрийн хувьд хувьсах мөнгөн гүйлгээний төлбөрийн эрсдэлд хейж хийхийн тулд тэрхүү өр төлбөртэй ижил үндсэн нөхцөлтэй бөгөөд ижил валютаар илэрхийлэгдсэн, тогтмол хүү төлөх ба хөвөх хүү хүлээн авах, таван жилийн хугацаатай хүүний түвшний свопын гэрээг байгуулсан. Анх үүсэх үед уг свопын бодит үнэ цэнэ нь тэг (0) байсан. Дараагийн тайлант үед свопын бодит үнэ цэнэ нь 49 ТН-ээр өссөн. Энэхүү өсөлт нь зах зээлийн хүүний түвшний өсөлтийн үр дүн болох 50 ТН-ийн өөрчлөлт ба уг свопын оролцогч нөгөө талын зээлийн эрсдлийн нэмэгдэлтийн үр дүн болох сөрөг 1 ТН-ийн өөрчлөлтөөс бүрдэж байна. Хөвөх хүүтэй өр төлбөрийн бодит үнэ цэнэ өөрчлөгдөөгүй боловч уг өр төлбөрийн хувьсах хүүний мөнгөн гүйлгээний эрсдлийг нөхөхөд шаардлагатай ирээдүйн мөнгөн гүйлгээний бодит үнэ цэнэ (өнөөгийн үнэ цэнэ) нь 50 ТН-ээр өссөн. Хэрэв А байгууллага нь тухайн хейжийг өндөр үр дүнтэй хэвээр байгаа гэж тодорхойлсон бол ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрвөл зохих үр дүнгүй байдал бий юу?**

Үгүй. Хэрэв үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн тодорхой хэсэг нь уг оролцогч нөгөө талын зээлийн эрсдэлд хамааруулж болох бол хүүний түвшний эрсдлийн хейж нь бүрэн үр дүнтэй гэж үзэхгүй (УСНББОУС 29-ийн МЗУ150-р параграф). Гэвч А байгууллага нь тухайн хейжийн харилцаа өндөр үр дүнтэй хэвээр байгаа гэж тодорхойлсон учраас уг свопын бодит үнэ цэнийн өөрчлөлтийн үр дүнтэй хэсгийг, өөрөөр хэлбэл, бодит үнэ цэнийн 49 ТН-ийн цэвэр өөрчлөлтийг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө. Хейжийн зүйлийн хувьсах хүүний мөнгөн гүйлгээний эрсдлийг нөхөхөд шаардлагатай ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийн хуримтлагдсан өөрчлөлт, өөрөөр хэлбэл 50 ТН нь уг хейжийн хэрэглүүрийн үнэ цэнийн хуримтлагдсан өөрчлөлт, өөрөөр хэлбэл 49 ТН-ээс илүү байгаа учраас тухайн свопын оролцогч нөгөө талын зээлийн чанарын доройтолтой холбоотой свопын бодит үнэ цэнийн өөрчлөлтийн хувьд ашиг, алдагдалд дебитлэх дүн байхгүй.

Дебит	Своп	49 ТН	
Кредит	Цэвэр хөрөнгө/өмч		49 ТН



Хэрэв А байгууллага нь уг хейж цаашид өндөр үр дүнтэй байхаа болисон гэж дүгнэсэн бол УСНББОУС 29-ийн 112-р параграфын дагуу тухайн хейж өндөр үр дүнтэй байхаа болисон өдрөөс эхлэн хейжийн нягтлан бодох бүртгэлийг зогсооно.

**Харин свопын бодит үнэ цэнэ нь 51 ТН болж өссөн бөгөөд түүний 50 ТН нь зах зээлийн хүүний түвшний өсөлтийн үр дүн, 1 ТН нь свопын оролцогч нөгөө талын зээлийн эрсдлийн бууралтын үр дүн болох хариулт нь өөрчлөгдөх үү?**

Тийм. Ийм тохиолдолд свопын оролцогч нөгөө талын зээлийн чанарын сайжралтанд хамааруулж болох уг свопын бодит үнэ цэнийн өөрчлөлтийн хувьд 1 ТН-ээр ашиг, алдагдалд кредитлэнэ. Яагаад гэвэл, уг хейжийн хэрэглүүрийн үнэ цэнийн хуримтлагдсан өөрчлөлт, өөрөөр хэлбэл 51 ТН нь хейжийн зүйлийн хувьсах хүүний мөнгөн гүйлгээний эрсдлийг нөхөхөд шаардлагатай ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийн хуримтлагдсан өөрчлөлт, өөрөөр хэлбэл 50 ТН-ээс илүү байна. Энэхүү зөрүү 1 ТН нь уг үүсмэл хейжийн хэрэглүүр буюу свопод хамааруулж болох илүүдэл үр дүнгүй байдлыг илэрхийлэх бөгөөд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Дебит	Своп	51 ТН	
Кредит	Цэвэр хөрөнгө/өмч		50 ТН
Кредит	Ашиг, алдагдал		1 ТН

### Е.5.3 Мөнгөн гүйлгээний Хейж: Хейжийн хэрэглүүрийн гүйцэтгэл (2)

20X1 оны 9 дүгээр сарын 30-д А байгууллага нь 24 баррел газрын тосны хувьд богино хугацаат форвард гэрээ байгуулснаар 20X2 оны 3 дугаар сарын 31-нд 24 баррел газрын тосыг борлуулах урьдчилан таамагласан борлуулалтандаа хейж хийжээ. Уг гэрээ нь тусгайлан заасан бараа бүтээгдэхүүний арилжаанд хамаарах газрын тосны ирээдүйн спот үнэ ба 1,000 ТН-ийн хоорондох зөрүүгээр тодорхойлогдох мөнгөөр цэвэр дүнгээр барагдуулахыг шаарддаг. А байгууллага нь газрын тосыг орон нутгийн өөр зах дээр борлуулахаар хүлээж байна. Форвард гэрээ нь уг урьдчилан таамагласан борлуулалтын хувьд үр дүнтэй хейж бөгөөд хейжийн нягтлан бодох бүртгэлийн бусад нөхцлүүд хангагдсан гэж А байгууллага нь тодорхойлсон. Тус байгууллага нь форвард гэрээний бодит үнэ цэнийн нийт өөрчлөлтийг уг хүлээгдэж буй мөнгөн орлогын гүйлгээний бодит үнэ цэнэтэй харьцуулснаар хейжийн үр дүнтэй байдлыг үнэлдэг. 12 дугаар сарын 31-нд газрын тосны спот үнэ нь орон нутгийн зах зээл болон хөрөнгийн биржийн аль алины хувьд өссөн. Орон нутгийн зах зээл дэх өсөлт нь хөрөнгийн бирж дээрх өсөлтөөс илүү байна. Үүний үр дүнд, орон нутгийн зах зээл дээрх борлуулалтаас олохоор хүлээгдэж буй мөнгөн орлогын гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ нь 1,100 ТН болсон. А байгууллагын форвард гэрээний бодит үнэ цэнэ нь сөрөг 80 ТН байв. Хейж нь өндөр үр дүнтэй хэвээр байгаа гэж А байгууллага тодорхойлсон гэж үзвэл ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрвөл зохих хейжийн үр дүнгүй байдал бий юу?

Үгүй. Мөнгөн гүйлгээний хейжийн хувьд, уг хейж хийсэн мөнгөн гүйлгээний бодит үнэ цэнийн хуримтлагдсан өөрчлөлт нь хейжийн хэрэглүүрийн үнэ цэнийн хуримтлагдсан өөрчлөлтөөс илүү байх тохиолдолд үр дүнгүй байдлыг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрдөггүй. Энэ тохиолдолд форвард гэрээний бодит үнэ цэнийн хуримтлагдсан өөрчлөлт нь 80 ТН, харин хейжийн зүйлийн хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн гүйлгээний хуримтлагдсан өөрчлөлт нь 100 ТН байна. Тухайн

хейж үүссэн өдрөөс эхлэн уг хейжийн зүйлийн хүлээгдэж буй ирээдүйн мөнгөн гүйлгээний хуримтлагдсан өөрчлөлтийн бодит үнэ цэнэ нь хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хуримтлагдсан өөрчлөлтөөс (үнэмлэхүй дүн) илүү байх учраас тэрхүү хейжийн хэрэглүүрийн олз, гарзын ямар нэг хэсгийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөхгүй (УСНББОУС 29-ийн 106(б) параграф). А байгууллага нь уг хейжийн харилцаа өндөр үр дүнтэй хэвээр байгаа гэж тодорхойлсон учраас форвард гэрээний бодит үнэ цэнийн нийт өөрчлөлтийг (80 TH) цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө.

Дебит	Цэвэр хөрөнгө/өмч	80 TH	
Кредит	Форвард		80 TH

Хэрэв А байгууллага нь уг хейж цаашид өндөр үр дүнтэй байхаа болисон гэж дүгнэсэн бол УСНББОУС 29-ийн 112-р параграфын дагуу тухайн хейж өндөр үр дүнтэй байхаа болисон өдрөөс эхлэн хейжийн нягтлан бодох бүртгэлийг зогсооно.

#### **Е.5.4 Мөнгөн гүйлгээний хейж: Тусгайлан заасан хгацаанаас өмнө гарч тохиолдох урьдчилан таамагласан ажил гүйлгээ**

Бараа бүтээгдэхүүний урьдчилан таамагласан борлуулалт гэх мэт урьдчилан таамагласан ажил гүйлгээний мөнгөн гүйлгээний хейжид байгууллага нь үүсмэл хэрэглүүрийг хейжийн хэрэглүүр гэж сонгодог. Хейжийн харилцаа нь хейжийн нягтлан бодох бүртгэлийн бүх нөхлийг, үүн дотроо тухайн ажил гүйлгээ ул үндэслэлтэй тодорхой ба богино хугацааны муж дотор гарч тохиолдохоор хүлээгдэж буй хугацааг тодорхойлох болон баримтжуулах шаардлагыг хангадаг (Асуулт Е.2.17-г үзнэ үү). Хэрэв тухайн урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь дараагийн тайлант үед анх хүлээгдэж байснаас эрт гарч тохиолдохоор хүлээгдэж байвал энэхүү ажил гүйлгээ нь уг хейж хийж буй гэж сонгосон ажил гүйлгээтэй ижил гэж байгууллага нь дүгнэж болох уу?

Тийм. Урьдчилан таамагласан ажил гүйлгээний хугацааны өөрчлөлт нь хейжийн сонголтын хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй. Гэвч энэ нь хейжийн харилцааны үр дүнтэй байдлын үнэлгээнд нөлөөлж болох юм. Хейжийн хэрэглүүр болох шалгуурыг хангасан хэвээр байхын тулд түүний оршин байдлын үлдсэн бүх хугацааны туршид уг хейжийн хэрэглүүрийг мөн хейжийн хэрэглүүр гэж сонгох шаардлагатай байдаг (УСНББОУС 29-ийн 84-р параграф ба Асуулт Е.2.17-г үзнэ үү).

#### **Е.5.5 Мөнгөн гүйлгээний хейж: Өрийн хэрэглүүрийн урьдчилан таамагласан ажил гүйлгээний хейжийн хувьд үр дүнтэй байдлыг хэмжих**

Холбогдох хүүний төлбөрүүд нь тухайн урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдох үед оршин байх зах зээлийн хүүний түвшинд үндэслэх учраас хүүтэй хөрөнгөнд оруулах урьдчилан таамагласан хөрөнгө оруулалт эсвэл хүүтэй өр төлбөрийн урьдчилан таамагласан гаргалт нь хүүний түвшний өөрчлөлтөөс хамаарах мөнгөн гүйлгээний эрсдэл үүсгэдэг. Хүүний түвшний өөрчлөлтөнд хамаарах эрсдлийн мөнгөн гүйлгээний хейжийн зорилго нь уг урьдчилан таамагласан ажил гүйлгээний нөхцөл ба хугацаатай уялдсан нэг

**тогтмол хүүг, ихэвчлэн тухайн хейж үүсэх үед оршин байсан хүүний түвшинг гаргахын тулд тэрхүү хүүний түвшний ирээдүйн өөрчлөлтийн үр нөлөөг нөхөх явдал юм. Урьдчилан таамагласан ажил гүйлгээний зах зээлийн хүүний түвшин нь тухайн хейжийг дуусгавар болгох эсвэл урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдох үед хэд байхыг тэрхүү хейжийн хугацааны туршид тодорхойлох боломжгүй байдаг. Энэ тохиолдолд хейжийн үр дүнтэй байдлыг хэрхэн үнэлж, хэмжих вэ?**

Хейжийн сонголтын өдөр ба түүний үр дүнтэй байдлын завсрын хэмжилтийн өдрийн хоорондох хугацаанд хүүний түвшинд гарсан өөрчлөлтөнд үндэслэн үр дүнтэй байдлыг энэхүү тайлант үеийн туршид хэмжиж болно. Ийм хэмжилтийг хийхэд ашигласан хүүний түвшин нь тухайн хейж үүссэн өдрөөр оршин байсан болон хүүний түвшнүүдийн хугацааны бүтцээр илэрхийлэгдсэн уг хэмжилтийн өдөр оршин байх тэрхүү урьдчилан таамагласан ажил гүйлгээний хугацаа ба гарч тохиолдолттой уялдсан хүүний түвшин байна.

Төлснөөр эсвэл хүлээн авснаар уг үүсмэл хейжийн хэрэглүүрээс үүсэх мөнгөн гүйлгээтэй тэрхүү хейжийн зүйлийн мөнгөн гүйлгээг зөвхөн харьцуулах нь тэдгээр мөнгөн гүйлгээ дараагийн тайлант үеүдэд нөхөгдөх эсэх болон үүнээс хамааран аливаа үр дүнгүй байдал үүсэх эсэх талаархи тухайн байгууллагын хүлээлтийг харгалзан үздэггүй учраас энэ хандлага нь ерөнхийдөө хангалтгүй байдаг.

Дараах хэлэлцүүлэг нь мөнгөн гүйлгээний хейжийг тогтоох ба түүний үр дүнтэй байдлыг хэмжих механизмыг үлгэрчлэн харуулна. Энэ үлгэрчилсэн жишээний зорилгоор, тухайн байгууллага нь нэг жилийн хугацаатай, 100,000 ТН-ийн өрийн хэрэглүүрийг гурван сарын дараа гаргахаар төлөвлөсөн гэж үзье. Уг хэрэглүүр нь хүүг улирал тутам, үндсэн дүнг дуусгавар болох үед төлнө. Тус байгууллага нь хүүний түвшний өсөлтийн эрсдэлд өртөх бөгөөд хүүний түвшний свопоос эхэлсэн форвард гэрээ байгуулснаар уг өрийн хүүний мөнгөн гүйлгээний хейж хийдэг. Своп нь нэг жилийн хугацаатай бөгөөд уг урьдчилан таамагласан өрийн гаргалтын нөхцөлтэй уялдахын тулд гурван сарын дараа эхэлнэ. Байгууллага нь тогтмол хүү төлж, хувьсах хүү хүлээн авах бөгөөд хейж хийж буй эрсдлийг тухайн өрийн урьдчилан таамагласан гаргалтын ЛАЙБОР-т үндэслэсэн хүүний бүрэлдэхүүн хэсэг байдлаар сонгоно.

### *Өгөөжийн муруй*

Өгөөжийн муруй нь хейжийн харилцааны эхэнд ба түүний явцын аль алины хувьд ирээдүйн мөнгөн гүйлгээ болон ийм мөнгөн гүйлгээний бодит үнэ цэнийг тооцоолох суурь үндэслэлийг бүрдүүлдэг. Өгөөжийн муруй нь тухайн зах зээлд арилжиж буй, лавлагаа болгож болох бондын одоогийн зах зээлийн өгөөжид үндэслэдэг. Зах зээлийн өгөөжид хамаарах купоны төлбөрийн үр нөлөөг арилгах замаар тухайн зах зээлийн өгөөжийг спот хүүний түвшинд (“spot хүүний түвшин” буюу “тэг купонтой хүүний түвшин”-д) хөрвүүлдэг. Үндсэн дүн ба хүүний төлбөрүүд гэх мэт ирээдүйн мөнгөн гүйлгээний бодит үнэ цэнийг гаргахын тулд тэдгээрийг дискаунтчлахдаа спот хүүний түвшинг ашигладаг. Хувьсах болон ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээг тооцохдоо ашиглах форвард хүүний түвшинг тогтоохын тулд спот хүүний түвшинг бас ашигладаг. Спот хүүний түвшин ба нэг үет форвард хүүний түвшний хоорондох харилцааг дараах томъёогоор харуулав:

**Спот-форвард харилцаа**

$$F = \frac{(1 + SR_t)^t}{(1 + SR_{t-1})^{t-1}} - 1$$

Энд: F = форвард хүүний түвшин (%)  
 SR = спот хүүний түвшин (%)  
 t = хугацааны үе (жишээлбэл; 1, 2, 3, 4, 5)

Мөн үлгэрчилсэн жишээний зорилгын хувьд, улирал тутмын нийлмэл хүүг ашигласан хүүний түвшний улирлын хугацааны бүтэц нь уг хейжийн эхэнд дараах байдалтай байсан гэж үзье.

<b>Эхэн дэх өгөөжийн муруй – (Тайлант үе 1-ийн эхэнд)</b>					
<i>Форвардын тайлант үеүд</i>	1	2	3	4	5
Спот хүүний түвшин	3.75%	4.50%	5.50%	6.00%	6.25%
Форвард хүүний түвшин	3.75%	5.25%	7.51%	7.50%	7.25%

Нэг үет форвард хүүний түвшинг харгалзах дуусгавар болох хугацааны спот хүүний түвшинд үндэслэн тооцоолно. Жишээлбэл; тайлант үе 2-ын хувьд дээрх томъёог ашиглан тооцоолсон одоогийн форвард хүүний түвшин нь  $[1.0450^2/1.0375]-1=5.25$  хувь байна. Спот хүүний түвшин нь Тайлант үе 1-ийн эхнээс Тайлант үе 2-ын эцэс хүртэлх хүүний түвшин (spot), харин форвард хүүний түвшин нь Тайлант үе 2-ын эхнээс Тайлант үе 2-ын эцэс хүртэлх хүүний түвшин учраас Тайлант үе 2-ын нэг үет форвардын одоогийн хүүний түвшин нь Тайлант үе 2-ын одоогийн спот хүүний түвшнээс өөр байна.

*Хейжийн зүйл*

Энэ жишээнд байгууллага нь улирал тутам төлөгдөх хүүтэй, нэг жилийн хугацаатай, 100,000 ТН-ийн өрийн хэрэглүүрийг гурван сарын дараа гаргахаар төлөвлөж байна. Тус байгууллага нь хүүний түвшний өсөлтийн эрсдэлд өртөх бөгөөд уг урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдохын өмнө үүсэж болох хүүний түвшний өөрчлөлтийн мөнгөн гүйлгээнд үзүүлэх үр нөлөөг арилгахыг хүсэж байна. Хэрэв уг эрсдлийг арилгавал байгууллага нь зах зээл дээр одоо бэлэн боломжтой байгаа нэг жилийн хугацаатай, форвардын гурван сарын дараах купоны хүүтэй тэнцүү хэмжээгээр өөрийн өрийн гаргалтын хүүний түвшинг тогтоох юм. Форвардын купоны хүүний түвшин нь форвард (spot) хүүний түвшнээс өөр бөгөөд дээр харуулсан хүүний түвшний хугацааны бүтцээс тооцоолвол 6.86 хувь байна. Форвардын купоны хүүний түвшин нь уг урьдчилан таамагласан өрийн хэрэглүүрийн нөхцлийг харгалзан тооцсон, тухайн хейжийн эхэн дэх зах зээлийн хүүний түвшин юм. Энэ нь өрийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг түүний гаргалтын үеийн нэрлэсэн дүнтэй тэнцүү болгох үр дүнтэй байна.

Хүүний түвшний хугацааны одоогийн бүтцэд үндэслэн уг өрийн хэрэглүүрийн хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг тэрхүү хейжийн харилцааны эхэнд тооцоолж болно. Энэхүү зорилгын хувьд, хүүний түвшин нь өөрчлөгдөхгүй бөгөөд уг өрийн хэрэглүүрийг Тайлант үе 2-ын эхэнд 6.86 хувиар гаргана гэж үзнэ. Энэ тохиолдолд,

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

өрийн хэрэглүүрийн мөнгөн гүйлгээ болон бодит үнэ цэнэ нь Тайлант үе 2-ын эхэнд дараах байдалтай байна.

<b>Тогтмол хүүтэй өрийн хэрэглүүрийн гаргалт Тайлант үе 2-ын эхэнд – Хүүний түвшний өөрчлөлтгүй (форвард хүүний түвшинд үндэслэсэн спот)</b>					
<i>Нийт дүн</i>					
<i>Форвардын анхны тайлант үеүд</i>	1	2	3	4	5
<i>Үлдсэн тайлант үеүд</i>	1	2	3	4	
Спот хүүний түвшин	5.25%	6.38%	6.75%	6.88%	
Форвард хүүний түвшин	5.25%	7.51%	7.50%	7.25%	
	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>
<i>Мөнгөн гүйлгээ:</i>					
Тогтмол хүү @6.86%		1,716	1,716	1,716	1,716
Үндсэн дүн					100,000
<i>Бодит үнэ цэнэ:</i>					
Хүү	6,592	1,694	1,663	1,632	1,603
Үндсэн дүн	93,408				93,408 <sup>(a)</sup>
Нийт дүн	100,000				
(a) $100,000 \text{ TH} / (1 + [0.0688/4])^4$					

Хүүний түвшин өөрчлөгдөхгүй гэж үзсэн учраас хүүний болон үндсэн дүнгийн бодит үнэ цэнэ нь уг урьдчилан таамагласан ажил гүйлгээний нэрлэсэн дүнтэй тэнцүү байна. Хэрэв өрийн хэрэглүүрийг уг урьдчилан таамагласан ажил гүйлгээний өдөр гаргасан бол мөнгөн гүйлгээ үүсэх байсан холбогдох тайлант үеүдийн хувьд тухайн хейжийн эхэнд оршин байсан спот хүүний түвшинд үндэслэн бодит үнэ цэнийн дүнг тооцоолно. Бодит үнэ цэнийн дүн нь уг өрийн хэрэглүүрийг гаргасны дараа үлдэх тайлант үеүүдэд үндэслэн тэдгээр мөнгөн гүйлгээг дискаунтчилсаны үр нөлөөг тусгадаг. Жишээлбэл; Тайлант үе 3-д төлөгдөхөөр хүлээгдэж буй хүүний мөнгөн гүйлгээг дискаунтчлахын тулд 6.38 хувь гэсэн спот хүүний түвшинг ашиглах боловч тухайн урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдсоны дараа хоёр тайлант үе үлдэх учраас үүнийг зөвхөн хоёр тайлант үеийн хувьд дискаунтчилна.

Хүүний түвшин өөрчлөгдөхгүй гэж үзсэн учраас форвард хүүний түвшин нь өмнө харуулсантай ижил байна. Спот хүүний түвшин нь өөр боловч үнэн хэрэгтээ өөрчлөгдөхгүй. Энэ нь нэг үет форвардын спот хүүний түвшинг илэрхийлэх бөгөөд харгалзах форвард хүүний түвшинд үндэслэнэ.

*Хейжийн хэрэглүүр*

Хейжийн зорилго нь урьдчилан таамагласан ажил гүйлгээ болон хейжийн хэрэглүүрийн хувьд хүүний ерөнхий түвшинг тогтоох явдал бөгөөд Тайлант үе 2-оос Тайлант үе 5-ын хоорондох хугацаанд энэ нь тухайн хейжийн эхэн дэх зах зээлийн хүүний түвшин буюу 6.86 хувьтай тэнцүү байна. 6.86 хувийн тогтмол хүүтэй, хүүний түвшний свопоос эхэлсэн форвард гэрээг байгуулснаар энэхүү зорилтыг ханган биелүүлнэ. Тухайн хейжийн эхэнд оршин байсан хүүний түвшний хугацааны бүтцэд үндэслэсэн хүүний түвшний своп нь ийм хүүтэй байх юм. Тухайн хейжийн эхэнд хүүний түвшний свопын тогтмол хүүний төлбөрүүдийн бодит үнэ цэнэ нь хувьсах хүүний төлбөрүүдийн бодит үнэ цэнэтэй тэнцүү байх бөгөөд үүний үр дүнд хүүний түвшний своп нь тэг (0) бодит үнэ цэнэтэй байна. Хүүний түвшний

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

свопын хүлээгдэж буй мөнгөн гүйлгээ болон холбогдох бодит үнэ цэнийн дүнг доор харуулав.

<b>Хүүний түвшний своп</b>					
<i>Нийт дүн</i>					
<i>Форвардын анхны тайлант үеүд</i>	1	2	3	4	5
<i>Үлдсэн тайлант үеүд</i>		1	2	3	4
	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>
<i>Мөнгөн гүйлгээ:</i>					
Тогтмол хүү @6.86%		1,716	1,716	1,716	1,716
Урьдчилан таамагласан хувьсах хүү		1,313	1,877	1,876	1,813
<i>Форвард хүүний түвшинд үндэслэсэн урьдчилсан таамаглал</i>		5.25%	7.51%	7.50%	7.25%
Цэвэр хүү		(403)	161	160	97
<i>Бодит үнэ цэнэ:</i>					
<i>Дискаунтын хувь (спот)</i>		5.25%	6.38%	6.75%	6.88%
Тогтмол хүү	6,592	1,694	1,663	1,632	1,603
Урьдчилан таамагласан хувьсах хүү	6,592	1,296	1,819	1,784	1,693
Хүүний түвшний свопын бодит үнэ цэнэ	0	(398)	156	152	90

Хейжийн эхэнд форвард свопын тогтмол хүү нь хэрэв уг байгууллага одоо оршин байгаа нөхцлийн дагуу тухайн өрийн хэрэглүүрийг гурван сарын дараа гаргаж чадвал хүлээн авах тогтмол хүүтэй тэнцүү байна.

*Хейжийн үр дүнтэй байдлыг хэмжих*

Хэрэв хүүний түвшин нь тухайн хейж эргэлтэнд байх тайлант үеийн туршид өөрчлөгдвөл хейжийн үр дүнтэй байдлыг янз бүрийн арга замаар хэмжиж болно.

Тайлант үе 2-ын эхэнд уг өрийн хэрэглүүрийг гаргахын яг өмнө тэрхүү хүүний түвшин нь дараах байдлаар өөрчлөгдсөн гэж үзье.

<b>Өгөөжийн муруй – Хүүний түвшин нь 200 суурь оноогоор нэмэгдсэн</b>					
<i>Форвардын тайлант үеүд</i>	1	2	3	4	5
<i>Үлдсэн тайлант үеүд</i>		1	2	3	4
Спот хүүний түвшин		5.75%	6.50%	7.50%	8.00%
Форвард хүүний түвшин		5.75%	7.25%	9.51%	9.50%

Хүүний түвшний шинэ нөхцлийн дагуу, 6.86 хувийн тогтмол хүү төлөх ба хувьсах хүү хүлээн авах бөгөөд хейжийн хэрэглүүр гэж сонгосон уг хүүний түвшний свопын бодит үнэ цэнэ нь дараах байдалтай байна.

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

<b>Хүүний түвшний свопын бодит үнэ цэнэ</b>						
<i>Нийт дүн</i>						
<i>Форвардын анхны тайлант үеүд</i>	1	2	3	4	5	
<i>Үлдсэн тайлант үеүд</i>		1	2	3	4	
	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>
<i>Мөнгөн гүйлгээ:</i>						
Тогтмол хүү @6.86%		1,716	1,716	1,716	1,716	
Урьдчилан таамагласан хувьсах хүү		1,438	1,813	2,377	2,376	
<i>Шинэ форвард хүүний түвшинд үндэслэсэн урьдчилсан таамаглал</i>		5.25%	7.25%	9.51%	9.50%	
<i>Цэвэр хүү</i>		(279)	97	661	660	
<i>Бодит үнэ цэнэ:</i>						
<i>Шинэ дискаунтын хувь (спот)</i>		5.75%	6.50%	7.50%	8.00%	
Тогтмол хүү	6,592	1,692	1,662	1,623	1,585	
Урьдчилан таамагласан хувьсах хүү	7,615	1,417	1,755	2,248	2,195	
<i>Цэвэр хүүний бодит үнэ цэнэ</i>	1,053	(275)	93	625	610	

Хейжийн үр дүнтэй байдлыг тооцоолохын тулд мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийн эсвэл уг хейж хийсэн урьдчилан таамагласан ажил гүйлгээний үнэ цэнийн өөрчлөлтийг хэмжих шаардлагатай юм. Энэхүү хэмжилтийг хийх хамгийн наад зах нь хоёр арга байдаг.

<b>Арга А: Өрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тооцоолох</b>						
<i>Нийт дүн</i>						
<i>Форвардын анхны тайлант үеүд</i>	1	2	3	4	5	
<i>Үлдсэн тайлант үеүд</i>		1	2	3	4	
	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>
<i>Мөнгөн гүйлгээ:</i>						
Тогтмол хүү @6.86%		1,716	1,716	1,716	1,716	
Үндсэн дүн						100,000
<i>Бодит үнэ цэнэ:</i>						
<i>Шинэ дискаунтын хувь (спот)</i>		5.75%	6.50%	7.50%	8.00%	
Хүү	6,562	1,692	1,662	1,623	1,585	
Үндсэн дүн	92,385					92,385 <sup>(a)</sup>
Нийт дүн	98,947					
Эхэн дэх бодит үнэ цэнэ	100,000					
Бодит үнэ цэнийн зөрүү	(1,053)					
(a) $100,000 \text{ TH} / (1 + [0.08/4])^4$						

А аргын дагуу, тухайн хейжийн харилцааны эхэнд байсан купоны хүүний түвшинтэй (6.86 хувь) тэнцүү хүү бүхий өрийн хэрэглүүрийн шинэ хүүний түвшний нөхцлөөр бодит үнэ цэнийн тооцооллыг хийнэ. Дээр үлгэрчлэн харуулсанчлан, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тодорхойлохын тулд тухайн хейжийн харилцааны эхэнд байсан хүүний түвшний хугацааны бүтцэд үндэслэн тооцсон, Тайлант үе 2-ын эхэн дэх хүлээгдэж буй бодит үнэ цэнэтэй энэхүү бодит үнэ цэнийг харьцуулж үзнэ. Свопын болон уг урьдчилан таамагласан ажил гүйлгээний хугацаа нь өөр хоорондоо яг уялдан тохирч байгаа учраас свопын бодит үнэ цэнийн өөрчлөлт ба өрийн хэрэглүүрийн хүлээгдэж буй бодит үнэ цэнийн өөрчлөлт хоорондох зөрүү нь энэ жишээний хувьд яг харилцан нөхөгдөж байна гэдгийг анхаарах хэрэгтэй.

<b>Арга Б: Мөнгөн гүйлгээний бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тооцоолох</b>					
	<i>Нийт дүн</i>				
<i>Форвардын анхны тайлант үеүд</i>	1	2	3	4	5
<i>Үлдсэн тайлант үеүд</i>		1	2	3	4
Эхэн дэх зах зээлийн хүүний түвшин		6.86%	6.86%	6.86%	6.86%
Одоогийн форвард хүүний түвшин		5.75%	7.25%	9.51%	9.50%
Хүүний түвшний зөрүү		1.11%	(0.39%)	(2.64%)	(2.64%)
Мөнгөн гүйлгээний зөрүү (үндсэн дүн х хүүний түвшин)		279 TH	(97 TH)	(661 TH)	(660 TH)

<b>Арга В: Мөнгөн гүйлгээний бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тооцоолох</b>					
	<i>Нийт дүн</i>				
<i>Дискаунтын хувь (спот)</i>		5.75%	6.50%	7.50%	8.00%
<i>Өөрчлөлтийн бодит үнэ цэнэ</i>	(1,053 TH)	275 TH	(93 TH)	(625 TH)	(610 TH)

Б аргын дагуу, хэрэв өрийн хэрэглүүрийг тухайн хейжийн эхэнд байсан зах зээлийн хүүний түвшнээр гаргасан бол тогтоогдох байсан хүүний түвшин ба уг үр дүнтэй байдлын хэмжилтийн өдрөөрх холбогдох тайлант үеүдийн форвард хүүний түвшин хоорондох зөрүүд үндэслэн тэрхүү мөнгөн гүйлгээний өөрчлөлтийн өнөөгийн үнэ цэнийг тооцоолдог. Хейжийн эхэнд байсан зах зээлийн хүүний түвшин нь гурван сарын дараа гаргах нэг жилийн хугацаатай форвард купоны хүү байна. Мөнгөн гүйлгээ гарч тохиолдохоор хүлээгдэж буй холбогдох тайлант үеүдийн хувьд мөнгөн гүйлгээний өөрчлөлтийн өнөөгийн үнэ цэнийг уг үр дүнтэй байдлын хэмжилтийн өдрөөр оршин байсан одоогийн спот хүүний түвшинд үндэслэн тооцоолно. Тухайн өрийн хэрэглүүрийн хейж хийсэн тогтмол хүү ба одоогийн хувьсах хүү хоорондох харьцуулалт нь хүүний түвшний свопын тогтмол болон хувьсах хүүний хэсгүүдийн мөнгөн гүйлгээний харьцуулалттай ижил учраас энэ аргыг “онолын своп”-ын арга (эсвэл “таамагласан үүсмэл хэрэглүүр”-ийн арга) гэж бас нэрлэж болно.

Хугацаанууд нь хоорондоо уялдан тохирч байгаа учраас свопын бодит үнэ цэнийн өөрчлөлт ба мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийн өөрчлөлт хоорондох зөрүү нь энэ жишээний хувьд өмнөхийн адилаар бие биенийгээ яг харилцан нөхнө.

#### *Бусад анхаарах зүйлс*

Урьдчилан таамагласан ажил гүйлгээний хүлээгдэж буй өдрөөс өмнөх үр дүнгүй байдлыг тооцоолохын тулд гүйцэтгэвэл зохих нэмэлт тооцоолол байдаг бөгөөд энэ үлгэрчилсэн жишээний зорилгын хувьд түүнийг харгалзан үзээгүй болно. Үлгэрчилсэн жишээ бүрийн хувьд бодит үнэ цэнийн зөрүүг уг урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарахын яг өмнө, тэрхүү урьдчилан таамагласан ажил гүйлгээний хүлээгдэж буй өдрөөр, өөрөөр хэлбэл Тайлант үе 2-ын тодорхойлсон. Хэрэв хейжийн үр дүнтэй байдлын үнэлгээг уг урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдохоос өмнө хийсэн бол үр дүнгүй байдлын жинхэнэ дүнг гаргахын тулд тухайн зөрүүг одоогийн өдөр хүртэл дискаунтчилна. Жишээлбэл; хэмжилтийн өдөр нь тухайн хейжийн харилцааг тогтоосноос хойш нэг сарын дараа болох бөгөөд урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь хоёр сарын дараа гарч тохиолдоно гэж хүлээгдэж байгаа бол жинхэнэ бодит үнэ цэнийг гаргахын тулд тэрхүү урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдох хүртэл хүлээгдэж буй үлдсэн хоёр сарын хугацаанд уг дүнг дискаунтчилна. Дээр дурдсан жишээний хувьд үр дүнгүй байдал



САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

үүсээгүй учраас энэ алхам шаардлагагүй юм. Иймээс цэвэр дүнгээрээ тэг (0) байх дүнгүүдийг нэмж дискаунтчилах нь үр дүнд өөрчлөлт оруулахгүй.

Б аргын дагуу, хэрэв өрийн хэрэглүүрийг тухайн хейжийн эхэнд байсан зах зээлийн хүүний түвшнээр гаргасан бол тогтоогдох байсан хүүний түвшин ба уг үр дүнтэй байдлын хэмжилтийн өдрөөрх холбогдох тайлант үеүдийн форвард купоны хүүний түвшин хоорондох зөрүүд үндэслэн үр дүнгүй байдлыг тооцоолдог. Хэрэв хейжийн зорилго нь урьдчилан таамагласан цуврал хүүний төлбөрүүдийн хувьд нэг тогтмол хүүг тогтоох явдал бол хейжийн эхэнд байсан форвард хүүний түвшин ба үр дүнтэй байдлын хэмжилтийн өдрөөр оршин байх форвард хүүний түвшин хоорондох зөрүүд үндэслэн мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг тооцоолох нь тохиромжгүй юм. Дээрх жишээнд үлгэрчлэн харуулсанчлан, хүүний түвшний свопоор уг эрсдэлд хейж хийж, энэхүү зорилтыг биелүүлнэ. Свопын тогтмол хүүний түвшин нь тухайн свопын хугацаан дахь форвард хүүний түвшнүүдээс бүрдэх холимог хүүний түвшин байна. Өгөөжийн муруй нь жигд байхаас бусад тохиолдолд свопын нийт хугацаан дахь форвард хүүний түвшний эрсдэл ба свопын тогтмол хүүний түвшин хоорондох зэрэгцүүлэлт нь өөр өөр мөнгөн гүйлгээ бий болгох бөгөөд тэдгээрийн бодит үнэ цэнэ нь зөвхөн уг хейжийн харилцааны эхэнд тэнцүү байна. Энэхүү зөрүүг дараах хүснэгтэнд харуулав.

<i>Нийт дүн</i>					
<i>Форвардын анхны тайлант үеүд</i>	<i>1</i>	<i>2</i>	<i>3</i>	<i>4</i>	<i>5</i>
<i>Үлдсэн тайлант үеүд</i>		<i>1</i>	<i>2</i>	<i>3</i>	<i>4</i>
Эхэн дэх форвард хүүний түвшин		5.25%	7.51%	7.50%	7.25%
Одоогийн форвард хүүний түвшин		5.75%	7.25%	9.51%	9.50%
Хүүний түвшний зөрүү		(0.50%)	(0.26%)	(2.00%)	(2.25%)
Мөнгөн гүйлгээний зөрүү		(125 TH)	(64 TH)	(501 TH)	(563 TH)
(үндсэн дүн х хүүний түвшин)					
Дискаунтын хувь (спот)		5.75%	6.50%	7.50%	8.00%
Зөрүүний бодит үнэ цэнэ	(1,055TH)	(123 TH)	(62 TH)	(474 TH)	(520 TH)
Хүүний түвшний свопын бодит үнэ цэнэ	1,053 TH				
Үр дүнгүй байдал	(2 TH)				

Хейжийн зорилго нь хейжийн эхэнд байсан форвард хүүний түвшинг тогтоох явдал бол уг своп нь өөр өөр цуврал форвард хүүний түвшнүүдийг харилцан нөхөхгүй, холимог ганц тогтмол купоны хүүний түвшинтэй байх учраас уг хүүний түвшний своп нь үр дүнгүй байна. Харин хейжийн зорилго нь хейжийн эхэнд байсан форвард купоны хүүний түвшинг тогтоох явдал бол уг своп нь үр дүнтэй байх бөгөөд форвард хүүний түвшнүүдийн зөрүүд үндэслэсэн харьцуулалт нь үр дүнгүй байдлыг илэрхийлэх боловч ийм үр дүнгүй байх боломжгүй юм. Хэрэв хейжийн зорилго нь тэдгээр форвард хүүний түвшнүүдийг хэвээр хадгалах явдал бол уг хейжийн эхэнд байсан форвард хүүний түвшнүүд болон үр дүнтэй байдлын хэмжилтийн өдрөөр оршин байх форвард хүүний түвшнүүд хоорондох зөрүүд үндэслэн үр дүнгүй байдлыг тооцоолох нь үр дүнгүй байдлын тохиромжтой хэмжилт болно. Энэ тохиолдолд тохиромжтой хейжийн хэрэглүүр нь цуврал форвард гэрээнүүд байх бөгөөд тэдгээрийн тус бүрийн хугацаа нь дахин үнэ тогтоох өдөр дуусгавар болох ба уг урьдчилан таамагласан ажил гүйлгээний өдөртэй уялдан нийцсэн байна.

Хүүний түвшний свопын зөвхөн хувьсах мөнгөн гүйлгээг уг форвард хүүний түвшнээр бий болгох тухайн өрийн хүүний мөнгөн гүйлгээтэй харьцуулах нь тохиромжгүй гэдгийг мөн анхаарах хэрэгтэй. Ийм арга нь үүсмэл хэрэглүүрийн зөвхөн тодорхой хэсгийн хувьд үр дүнгүй байдлыг хэмжих үр нөлөөтэй байх бөгөөд УСНББОУС 29 нь энэ тохиолдолд үр дүнтэй байдлыг үнэлэх зорилгоор үүсмэл хэрэглүүрийг хуваахыг зөвшөөрдөггүй (УСНББОУС 29-ийн 83-р параграф). Гэвч хугацаа зөрүүгүй ба зээлийн эрсдэл өөрчлөгдөөгүй эсвэл тухайн хейжийн харилцаанд түүнийг сонгоогүй гэж үзвэл хүүний түвшний свопын тогтмол хүүний түвшин нь хейжийн эхэнд уг өрийн хэрэглүүрийн хувьд тогтоох байсан тогтмол хүүний түвшинтэй тэнцүү байх тохиолдолд үр дүнгүй байдал үүсэхгүй гэдгийг хүлээн зөвшөөрдөг.

**Е.5.6 Мөнгөн гүйлгээний хейж: Үндсэн хөрөнгийг гадаад валютаар худалдан авах арилжааны баталгаа**

**А байгууллагын бүртгэлийн болон толилуулгын валют нь орон нутгийн валют (ОНВ) юм. 20X2 оны 6 дугаар сарын 30-нд 100,000 гадаад валют (ГВ)-ыг хүлээн авах ба 109,600 ОНВ-ыг анхны өртгөөр өгч, тэг (0) бодит үнэ цэнэтэй байх форвард арилжааны гэрээг тус байгууллага нь 20X1 оны 6 дугаар сарын 30-нд байгуулсан. Байгууллага нь өөрийн цахилгаан түгээлтийн сүлжээнд зориулсан сэлбэгийг 20X2 оны 3 дугаар сарын 31-нд худалдан авах арилжааны баталгаа болон түүний үр дүнд 20X2 оны 6 дугаар сарын 30-нд төлөх 100,000 ГВ-ын өглөгийн мөнгөн гүйлгээний хейжид уг форвард арилжааны гэрээг хейжийн хэрэглүүр болгон сонгосон. УСНББОУС 29-д заасан хейжийн нягтлан бодох бүртгэлийн бүх шалгуур хангагдаж байна.**

Доорх хүснэгтэнд харуулсанчлан, 20X1 оны 6 дугаар сарын 30-нд спот арилжааны ханш нь 1 ГВ-ын хувьд 1.072 ОНВ, харин арван хоёр сарын хугацаатай форвард арилжааны ханш нь 1 ГВ-ын хувьд 1.096 ОНВ байсан. 20X1 оны 12 дугаар сарын 31-нд спот арилжааны ханш нь 1 ГВ-ын хувьд 1.080 ОНВ, харин зургаан сарын хугацаатай форвард арилжааны ханш нь 1 ГВ-ын хувьд 1.092 ОНВ байсан. 20X2 оны 3 дугаар сарын 31-нд спот арилжааны ханш нь 1 ГВ-ын хувьд 1.074 ОНВ, харин гурван сарын хугацаатай форвард арилжааны ханш нь 1 ГВ-ын хувьд 1.076 ОНВ байсан. 20X2 оны 6 дугаар сарын 30-нд спот арилжааны ханш нь 1 ГВ-ын хувьд 1.072 ОНВ болсон. Орон нутгийн валютаар илэрхийлэгдсэн холбогдох өгөөжийн муруй нь тухайн тайлант үеийн туршид жилийн 6 хувиар жигд байсан.

Форвард арилжааны гэрээний бодит үнэ цэнэ нь 20X1 оны 12 дугаар сарын 31-нд сөрөг 388 ОНВ  $\{[(1.092 \times 100,000) - 109,600]/1.06(6/12)\}$ , 20X2 оны 3 дугаар сарын 31-нд сөрөг 1.971 ОНВ  $\{[(1.076 \times 100,000) - 109,600]/1.06(3/12)\}$ , 20X2 оны 6 дугаар сарын 30-нд сөрөг 2.400 ОНВ  $\{(1.072 \times 100,000 - 109,600)\}$  тус тус байв.

Огноо	Спот ханш	20X2 оны 6-р сарын 30 хүртэлх форвард ханш	Форвард гэрээний бодит үнэ цэнэ
20X1 оны 6-р сарын 30	1.072	1.096	-
20X1 оны 12-р сарын 31	1.080	1.092	(388)
20X2 оны 3-р сарын 31	1.074	1.076	(1,971)
20X2 оны 6-р сарын 30	1.072	-	(2,400)

**Асуудал (а) – Форвард арилжааны гэрээний бодит үнэ цэнийн өөрчлөлтийн хувьд хейжийн харилцааг сонгосон ба байгууллага нь уг хейж хийсэн урьдчилан таамагласан ажил гүйлгээний үр дүн болох санхүүгийн бус хөрөнгөнд суурийн тохируулга хийх нягтлан бодох бүртгэлийн бодлоготой бол эдгээр ажил гүйлгээг хэрхэн бүртгэх вэ?**

Нягтлан бодох бүртгэлийн бичилт нь дараах байдалтай байна.

**20X1 оны 6 дугаар сарын 30**

Дебит	Форвард	0 ОНВ	
Кредит	Мөнгө		0 ОНВ

*Форвард арилжааны гэрээг түүний анхны тэг (0) дүнгээр бүртгэх (УСНББОУС 29-ийн 45-р параграф). Форвард арилжааны гэрээ ба худалдан авалтын гэрээний гол чухал нөхцлүүд ижил бөгөөд хейжийн үр дүнтэй байдлын үнэлгээ нь форвард үнэд үндэслэх учраас уг хейжийг бүрэн үр дүнтэй гэж үзнэ (УСНББОУС 29-ийн МЗУ149-р параграф).*

**20X1 оны 12 дугаар сарын 31**

Дебит	Цэвэр хөрөнгө/өмч	388 ОНВ	
Кредит	Форвард өр төлбөр		388 ОНВ

*20X1 оны 6-р сарын 30-наас 20X1 оны 12-р сарын 31-ний хооронд форвард арилжааны гэрээний бодит үнэ цэнэд гарсан өөрчлөлтийг, өөрөөр хэлбэл  $388 \text{ ОНВ} - 0 = 388 \text{ ОНВ}$ -ыг цэвэр хөрөнгө/өмчид бүртгэх (УСНББОУС 29-ийн 106-р параграф). Форвард арилжааны гэрээний гарз (388 ОНВ) нь уг форвард үнэд үндэслэсэн тэрхүү худалдан авалтын гэрээтэй холбоотой мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг яг нөхөх учраас хейж нь бүрэн үр дүнтэй байна  $[(388 \text{ ОНВ}) = \{([1.092 \times 100,000] - 109,600)/1.06(6/12)\} - \{([1.096 \times 100,000] - 109,600)/1.06\}]$ .*

**20X2 оны 3 дугаар сарын 31**

Дебит	Цэвэр хөрөнгө/өмч	1,583 ОНВ	
Кредит	Форвард өр төлбөр		1,583 ОНВ

*20X2 оны 1-р сарын 01-нээс 20X2 оны 3-р сарын 31-ний хооронд форвард арилжааны гэрээний бодит үнэ цэнэд гарсан өөрчлөлтийг (өөрөөр хэлбэл,  $1,971 \text{ ОНВ} - 388 \text{ ОНВ} = 1,583 \text{ ОНВ}$ ) цэвэр хөрөнгө/өмчид бүртгэх (УСНББОУС 29-ийн 106-р параграф). Форвард арилжааны гэрээний гарз (1,583 ОНВ) нь уг форвард үнэд үндэслэсэн тэрхүү худалдан авалтын гэрээтэй холбоотой мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг яг нөхөх учраас хейж нь бүрэн үр дүнтэй байна  $[(1,583 \text{ ОНВ}) = \{([1.076 \times 100,000] - 109,600)/1.06(3/12)\} - \{([1.092 \times 100,000] - 109,600)/1.06(6/12)\}]$ .*

Дебит	Үндсэн хөрөнгө (худалдан авалтын үнэ)	107,400 ОНВ	
Дебит	Үндсэн хөрөнгө (хейжийн гарз)	1,971 ОНВ	
Кредит	Цэвэр хөрөнгө/өмч		1,971 ОНВ
Кредит	Өглөг		107,400 ОНВ

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

Сэлбээгийн худалдан авалтыг спот ханшаар (1.074 x 100,000 ГВ) хүлээн зөвшөөрөх ба цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрч байсан уг форвард арилжааны гэрээний хуримтлагдсан гарзыг (1,971 ОНВ) хасаж, тэрхүү худалдан авсан сэлбээгийн анхны хэмжилтэнд тусган оруулах. Иймээс уг 109,371 ОНВ-ын анхны хэмжилтийн дүн нь 107,400 ОНВ-ын худалдан авалтын төлбөр ба 1,971 ОНВ-ын хейжийн гарзаас бүрдэнэ.

**20X2 оны 6 дугаар сарын 30**

Дебит	Өглөг	107,400 ОНВ	
Кредит	Мөнгө		107,200 ОНВ
Кредит	Ашиг, алдагдал		200 ОНВ

Өглөгийн спот ханшаар (100,000 ГВ x 1.072 = 107,200) барагдуулалт ба холбогдох 200 ОНВ-ын (107,400 ОНВ – 107,200 ОНВ) ханшийн олзыг бүртгэх.

Дебит	Ашиг, алдагдал	429 ОНВ	
Кредит	Форвард өр төлбөр		429 ОНВ

20X2 оны 4-р сарын 01-нээс 20X2 оны 6-р сарын 30-ны хооронд форвард арилжааны гэрээнээс үүссэн гарзыг (өөрөөр хэлбэл, 2,400 ОНВ – 1,971 ОНВ = 429 ОНВ) ашиг, алдагдалд бүртгэх. Форвард арилжааны гэрээний гарз (429 ОНВ) нь уг форвард үнэд үндэслэсэн тэрхүү өглөгийн бодит үнэ цэнийн члөлтийг яг нөхөх учраас хейж нь бүрэн үр дүнтэй гэж үзнэ [(429 ОНВ = ([1.072 x 100,000] – 109,600 – {[1.076 x 100,000] – 109,600})/1.06(3/12))].

Дебит	Форвард өр төлбөр	2,400 ОНВ	
Кредит	Мөнгө		2,400 ОНВ

Форвард арилжааны гэрээний цэвэр барагдуулалтыг бүртгэх.

**Асуудал (б) – Форвард арилжааны гэрээний спот элементийн өөрчлөлтийн хувьд хейжийн харилцааг сонгосон ба хүүний элементийг уг сонгосон хейжийн харилцаанд оруулаагүй бол эдгээр ажил гүйлгээг хэрхэн бүртгэх вэ?**

Нягтлан бодох бүртгэлийн бичилт нь дараах байдалтай байна.

**20X1 оны 6 дугаар сарын 30**

Дебит	Форвард	0 ОНВ	
Кредит	Мөнгө		0 ОНВ

Форвард арилжааны гэрээг түүний анхны тээ (0) дүнгээр бүртгэх (УСНББОУС 29-ийн 45-р параграф). Форвард арилжааны гэрээ ба худалдан авалтын гэрээний гол чухал нөхцлүүд ижил бөгөөд форвард гэрээний урамшуулал буюу хөнгөлөлтийн өөрчлөлтийг уг хейжийн үр дүнтэй байдлын үнэлгээнд оруулахгүй учраас тэрхүү хейжийг бүрэн үр дүнтэй гэж үзнэ (УСНББОУС 29-ийн МЗУ149-р параграф).

**20X1 оны 12 дугаар сарын 31**

Дебит	Ашиг, алдагдал (хүүний элемент)	1,165 ОНВ	
Кредит	Цэвэр хөрөнгө/өмч (spot элемент)		777 ОНВ
Кредит	Форвард өр төлбөр		388 ОНВ

20X1 оны 6-р сарын 30-наас 20X1 оны 12-р сарын 31-ний хооронд форвард арилжааны гэрээний бодит үнэ цэнэд гарсан өөрчлөлтийг, өөрөөр хэлбэл  $388 \text{ ОНВ} - 0 = 388 \text{ ОНВ}$ -ыг бүртгэх. Форвард арилжааны гэрээний spot барагдуулалтын өнөөгийн үнэ цэнийн өөрчлөлт нь  $777 \text{ ОНВ}$ -ын  $\{([1.080 \times 100,000] - 107,200)/1.06(6/12)\} - \{([1.072 \times 100,000] - 107,200)/1.06\}$  олз байх бөгөөд цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө (УСНББОУС 29-ийн 106-р параграф). Форвард арилжааны гэрээний хүүний элементийн өөрчлөлт (бодит үнэ цэнийн үлдэх өөрчлөлт) нь  $1,165 (388 + 777) \text{ ОНВ}$ -ын гарз бөгөөд үүнийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн (УСНББОУС 29-ийн 83-р параграф ба УСНББОУС 29-ийн 64(а) параграф). Форвард арилжааны гэрээний spot элементийн олз ( $777 \text{ ОНВ}$ ) нь уг spot ханшаар илэрхийлэгдсэн худалдан авалтын үнийн өөрчлөлтийг ( $777 \text{ ОНВ} = \{([1.080 \times 100,000] - 107,200)/1.06(6/12)\} - \{([1.072 \times 100,000] - 107,200)/1.06\}$ ) яг нөхөх учраас хейж нь бүрэн үр дүнтэй байна.

**20X2 оны 3 дугаар сарын 31**

Дебит	Цэвэр хөрөнгө/өмч (spot элемент)	580 ОНВ	
Дебит	Ашиг, алдагдал (хүүний элемент)	1,003 ОНВ	
Кредит	Форвард өр төлбөр		1,583 ОНВ

20X2 оны 1-р сарын 01-нээс 20X2 оны 3-р сарын 31-ний хооронд форвард арилжааны гэрээний бодит үнэ цэнэд гарсан өөрчлөлтийг (өөрөөр хэлбэл,  $1,971 \text{ ОНВ} - 388 \text{ ОНВ} = 1,583 \text{ ОНВ}$ ) бүртгэх. Форвард арилжааны гэрээний spot барагдуулалтын өнөөгийн үнэ цэнийн өөрчлөлт нь  $580 \text{ ОНВ}$ -ын  $\{([1.074 \times 100,000] - 107,200)/1.06(3/12)\} - \{([1.080 \times 100,000] - 107,200)/1.06(6/12)\}$  гарз байх бөгөөд үүнийг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө (УСНББОУС 29-ийн 106(а) параграф). Форвард арилжааны гэрээний хүүний элементийн өөрчлөлт (бодит үнэ цэнийн үлдэх өөрчлөлт) нь  $1,003 \text{ ОНВ} (1,583 \text{ ОНВ} - 580 \text{ ОНВ})$ -ын гарз бөгөөд үүнийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн (УСНББОУС 29-ийн 83-р параграф ба УСНББОУС 29-ийн 64(а) параграф). Форвард арилжааны гэрээний spot элементийн гарз ( $580 \text{ ОНВ}$ ) нь уг spot ханшаар илэрхийлэгдсэн худалдан авалтын үнийн өөрчлөлтийг  $[(580) = \{([1.074 \times 100,000] - 107,200)/1.06(3/12)\} - \{([1.080 \times 100,000] - 107,200)/1.06(6/12)\}]$  яг нөхөх учраас хейж нь бүрэн үр дүнтэй байна.

Дебит	Үндсэн хөрөнгө (худалдан авалтын үнэ)	107,400 ОНВ	
Дебит	Цэвэр хөрөнгө/өмч	197 ОНВ	
Кредит	Үндсэн хөрөнгө (хейжийн олз)		197 ОНВ
Кредит	Өглөг		107,400 ОНВ

Сэлбэгийн худалдан авалтыг spot ханшаар ( $=1.074 \times 100,000 \text{ ГВ}$ ) хүлээн зөвшөөрөх ба цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрч байсан уг форвард арилжааны гэрээний spot элементийн хуримтлагдсан олзыг ( $777 \text{ ОНВ} -$

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

580 ОНВ = 197 ОНВ) хасаж, тэрхүү худалдан авсан сэлбэгийн анхны хэмжилтэнд тусган оруулах. Иймээс уг сэлбэгийн анхны хэмжилт нь 107,203 ОНВ байх бөгөөд 107,400 ОНВ-ын худалдан авалтын төлбөр, 197 ОНВ-ын хейжийн олзоос бүрдэнэ.

**20X2 оны 6 дугаар сарын 30**

Дебит	Өглөг	107,400 ОНВ	
Кредит	Мөнгө		107,200 ОНВ
Кредит	Ашиг, алдагдал		200 ОНВ

Өглөгийн спот ханшаар (100,000 ГВ х 1.072 = 107,200) барагдуулалт ба холбогдох 200 ОНВ-ын  $(-[1.072 - 1.074] \times 100,000 \text{ ГВ})$  ханшийн олзыг бүртгэх.

Дебит	Ашиг, алдагдал (спот элемент)	197 ОНВ	
Дебит	Ашиг, алдагдал (хүүний элемент)	232 ОНВ	
Кредит	Форвард өр төлбөр		429 ОНВ

20X2 оны 4-р сарын 01-нээс 20X2 оны 6-р сарын 30-ны хооронд форвард арилжааны гэрээний бодит үнэ цэнэд гарсан өөрчлөлтийг (өөрөөр хэлбэл, 2,400 ОНВ – 1,971 ОНВ = 429 ОНВ) бүртгэх. Форвард арилжааны гэрээний спот барагдуулалтын өнөөгийн үнэ цэнийн өөрчлөлт нь 197 ОНВ-ын  $([1.072 \times 100,000] - 107,200 - \{[1.074 \times 100,000] - 107,200\} / 1.06(3/12))$  гарз бөгөөд үүнийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Форвард арилжааны гэрээний хүүний элементийн өөрчлөлт (бодит үнэ цэнийн үлдэх өөрчлөлт) нь 232 ОНВ (429 ОНВ – 197 ОНВ)-ын гарз бөгөөд үүнийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн. Форвард арилжааны гэрээний спот элементийн гарз (197 ОНВ) нь уг өглөгийн спот барагдуулалтын өнөөгийн үнэ цэнийн өөрчлөлтийг  $(197 \text{ ОНВ}) = \{[1.072 \times 100,000] - 107,200 - \{[1.074 \times 100,000] - 107,200\} / 1.06(3/12)\}$  яг нөхөх учраас хейж нь бүрэн үр дүнтэй байна.

Дебит	Форвард өр төлбөр	2,400 ОНВ	
Кредит	Мөнгө		2,400 ОНВ

Форвард арилжааны гэрээний цэвэр барагдуулалтыг бүртгэх.

Хейжийн харилцааны нийт хугацааны туршид уг хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэд гарсан өөрчлөлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн товчоог дараах хүснэгтэнд харуулав. Хейжийн харилцааг сонгох арга зам нь тухайн хейжийн харилцаа, үүн дотроо хейжийн үр дүнтэй байдлын үнэлгээ болон олз, гарзын хүлээн зөвшөөрөлтийн дараагийн тайлант үеийн бүртгэлд нөлөө үзүүлдэг болохыг энэ хүснэгтэнд үлгэрчлэн харуулав.

Дуусгавар болсон тайлант үе	Спот барагдуулалтын өөрчлөлт	Спот барагдуулалтын өөрчлөлтийн бодит үнэ цэнэ	Форвард барагдуулалтын өөрчлөлт	Форвард барагдуулалтын өөрчлөлтийн бодит үнэ цэнэ	Хүүний элементийн өөрчлөлтийн бодит үнэ цэнэ
	ОНВ	ОНВ	ОНВ	ОНВ	ОНВ
20X1 оны 6-р сар	-	-	-	-	-
20X1 оны 12-р сар	800	777	(400)	(388)	(1,165)
20X2 оны 3-р сар	(600)	(580)	(1,600)	(1,583)	(1,003)
20X2 оны 6-р сар	(200)	(197)	(400)	(429)	(232)
<b>Нийт дүн</b>	-	-	<b>(2,400)</b>	<b>(2,400)</b>	<b>(2,400)</b>

Е.6 Хейж: Бусад асуудал

Е.6.1 Хейжийн нягтлан бодох бүртгэл: Сангийн яам гэх мэт байгууллагын хүүний түвшний эрсдлийн удирдлага

Сангийн яам гэх мэт байгууллага нь өөрийн бүх буюу зарим үйл ажиллагааны хувьд хүүний түвшний эрсдэлд өртөлтийг ихэвчлэн цэвэр дүнгээр удирдан зохицуулдаг. Тэд өөрсдийн санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөр, форвард баталгаа, үүн дотроо зээл олгох баталгааны талаархи гол чухал мэдээллийг тухайн байгууллагын хэмжээнд хуримтлуулан бүрдүүлэх системтэй байдаг. Мөнгөн гүйлгээг тооцоолж, нэгтгэх ба тэдгээрийг төлөх эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй ирээдүйн холбогдох тайлант үеүдэд уг тооцоолсон мөнгөн гүйлгээг хуваарилахын тулд энэхүү мэдээллийг ашигладаг. Тус систем нь тухайн хэрэглүүрүүдийн гэрээний нөхцөл болон бусад хүчин зүйлсэд, үүн дотроо урьдчилсан төлөлт ба үл төлөлтийн тооцоололд үндэслэн ийм мөнгөн гүйлгээний тооцооллыг хийдэг. Эрсдлийн удирдлагын зорилгоор, олон байгууллага нь хүүний түвшний зарим буюу бүх эрсдлийг цэвэр дүнгээр харилцан нөхөхийн тулд үүсмэл гэрээг ашигладаг.

Хэрэв байгууллага нь хүүний түвшний эрсдлийг цэвэр дүнгээр удирдан зохицуулдаг бол түүний үйл ажиллагаа нь УСНББОУС 29-ын дагуу хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангах боломжтой юу?

Тийм. Гэвч эрсдлийн удирдлагын зорилгоор цэвэр төлөв байдалд хейж хийдэг үүсмэл хейжийн хэрэглүүр нь хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангахын тулд тэрхүү цэвэр төлөв байдлыг үүсгэж буй хөрөнгө, өр төлбөр, урьдчилан таамагласан мөнгөн орлогын гүйлгээ эсвэл урьдчилан таамагласан мөнгөн зарлагын гүйлгээтэй холбоотой нийт төлөв байдлын хейж гэж нягтлан бодох бүртгэлийн зорилгоор сонгогдсон байх ёстой (УСНББОУС 29-ийн 94-р параграф, УСНББОУС 29-ийн МЗУ141-р параграф, УСНББОУС 29-ийн МЗУ154-р параграф). Хейжийн олз, гарзыг тухайн хейж хийж буй тодорхой зүйлд хамааруулах ба ингэснээр ийм олз, гарзыг нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх тайлант үеийг бодитойгоор тодорхойлж чадахгүй учраас цэвэр төлөв байдлыг УСНББОУС 29-ийн дагуу хейжийн зүйл гэж сонгох боломжгүй юм.

Хейжийн үйл ажиллагааны зорилго нь тухайн байгууллагын ашиг, алдагдалд эцэстээ нөлөө үзүүлэх тусгай, тодорхойлсон ба сонгосон эрсдэл өртөлтийг харилцан нөхөх (УСНББОУС 29-ийн МЗУ153-р параграф) явдал бөгөөд байгууллага

нь өөрийн хүүний түвшний эрсдэл өртөлтийг нийт дүнгээр сонгож, баримтжуулдаг бол УСНББОУС 29-ийн 98-р параграфт заасан хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангахын тулд хүүний түвшний эрсдлийн цэвэр өртөлтийн хейжийг ямагт тодорхойлж, баримтжуулж болох юм. Мөн хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангахын тулд тухайн мэдээллийн систем нь мөнгөн гүйлгээний дүн ба цаг хугацаа, түүнчлэн өөрсдийн зорилтыг биелүүлэх эрсдлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүнтэй байдлын талаар хангалттай мэдээллийг цуглуулдаг байх ёстой.

Хэрэв байгууллага нь хүүний түвшний эрсдлийг цэвэр дүнгээр удирдан зохицуулдаг бол хейжийн нягтлан бодох бүртгэлийн зорилгоор түүний харгалзан үзэх шаардлагатай хүчин зүйлсийг Асуулт Е.6.2-т авч хэлэлцсэн.

#### **Е.6.2 Хүүний түвшний эрсдлийг цэвэр дүнгээр удирдан зохицуулдаг үеийн хейжийн нягтлан бодох бүртгэлийн анхаарах зүйлс**

**Хэрэв байгууллага нь хүүний түвшний эрсдлийг цэвэр дүнгээр удирдан зохицуулдаг бол хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангахын тулд өөрийн хүүний түвшний эрсдлийн удирдагын үйл ажиллагааг тодорхойлж, баримтжуулах болон хейжийн харилцааг тогтоож, тайлагнахдаа түүний харгалзан үзвэл зохих асуудлууд юу байх вэ?**

Гол асуудлуудыг доорх Асуудал (а) - (н)-д авч үзсэн. Нэгдүгээрт, хүүний түвшний эрсдлийн удирдлагын үйл ажиллагаанд ашигласан үүсмэл хэрэглүүрийг бодит үнэ цэнийн хейж эсвэл мөнгөн гүйлгээний хейж гэж сонгох эсэхийг Асуудал (а) ба (б)-д авч хэлэлцэнэ. Эдгээр асуудалд дурдсанчлан, хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуур үзүүлэлт ба нягтлан бодох бүртгэлийн үр дүн нь бодит үнэ цэнийн хейж болон мөнгөн гүйлгээний хейжийн хувьд ялгаатай байдаг. Хүүний түвшний эрсдлийн удирдлагын үйл ажиллагаанд ашигласан үүсмэл хэрэглүүрийг мөнгөн гүйлгээний хейжийн хэрэглүүр гэж сонговол хейжийн нягтлан бодох бүртгэлийн арга хандлагыг ашиглахад илүү хялбар байж болох учраас мөнгөн гүйлгээний хейжийн нягтлан бодох бүртгэлийн янз бүрийн төлөв байдлуудыг Асуудал (в) - (н)-д өргөжүүлэн авч үзсэн. УСНББОУС 29-д заасан хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг мөнгөн гүйлгээний хейжид мөрдөх талаар Асуудал (в) - (е)-д, нягтлан бодох бүртгэлийн шаардлагатай арга хандлагыг Асуудал (ж) болон (и)-д авч хэлэлцсэн. Эцэст нь, мөнгөн гүйлгээний хейжийн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой бусад тусгай асуудлуудыг Асуудал (к) - (н)-д авч үзэнэ.

**Асуудал (а) –Хүүний түвшний эрсдлийг цэвэр дүнгээр удирдан зохицуулахад ашигладаг үүсмэл хэрэглүүрийг нийт эрсдлийн бодит үнэ цэнийн хейжид эсвэл мөнгөн гүйлгээний хейжид УСНББОУС 29-ийн дагуу хейжийн хэрэглүүр гэж сонгож болох уу?**

Сонголтын хоёр төрлийн аль аль нь УСНББОУС 29-ийн дагуу боломжтой юм. Хүүний түвшний эрсдлийн удирдлагын үйл ажиллагаанд ашигласан үүсмэл хэрэглүүрийг байгууллага нь хөрөнгө, өр төлбөр, арилжааны баталгааны бодит үнэ цэнийн хейж гэж, эсвэл мөнгөн орлогын гүйлгээний урьдчилан таамагласан дахин хөрөнгө оруулалт, санхүүгийн өр төлбөрийн урьдчилан таамагласан дахин санхүүжилт буюу дараагийн тайлант үед шилжүүлэлт, хөрөнгө буюу өр төлбөрийн



хүүний түвшинг дахин тогтоосны мөнгөн гүйлгээний үр дагавар гэх мэт урьдчилан таамагласан ажил гүйлгээний мөнгөн гүйлгээний хейж гэж сонгож болох юм.

Эдийн засгийн утгаараа, үүсмэл хэрэглүүрийг бодит үнэ цэнийн хейж эсвэл мөнгөн гүйлгээний хейж гэж үзэх эсэх нь ялгаагүй байдаг. Эрсдлийн талаас авч үзвэл, үүсмэл хэрэглүүр нь цэвэр эрсдлийг бууруулах эдийн засгийн нэг ижил үр дагавартай байдаг. Жишээлбэл; тогтмол хүү хүлээн авах ба хувьсах хүү төлөх хүүний түвшний свопыг хувьсах хүүтэй хөрөнгийн мөнгөн гүйлгээний хейж эсвэл тогтмол хүүтэй өр төлбөрийн бодит үнэ цэнийн хейж гэж үзэж болно. Аль ч талаас авч үзсэн, хүүний түвшний свопын бодит үнэ цэнэ эсвэл мөнгөн гүйлгээ нь хүүний түвшний өөрчлөлтийн эрсдлийг харилцан нөхдөг. Гэвч Асуудал (б)-д авч хэлэлцсэнчлэн, үүсмэл хэрэглүүрийг бодит үнэ цэнийн хейж эсвэл мөнгөн гүйлгээний хейж гэж сонгосноос хамааран нягтлан бодох бүртгэлийн үр дагавар нь өөр байдаг.

Үлгэрчлэн харуулвал: Сангийн яам нь хоёр жилийн дараа дуусгавар болох хугацаатай дараах хөрөнгө, өр төлбөртэй байв.

	Хувьсах хүү ТН	Тогтмол хүү ТН
Хөрөнгө	60	100
Өр төлбөр	(100)	(60)
<b>Цэвэр дүн</b>	<b>(40)</b>	<b>40</b>

Цэвэр эрсдэлд хейж хийхийн тулд байгууллага нь хувьсах хүү хүлээн авах ба тогтмол хүү төлөх, хоёр жилийн хугацаатай, 40 ТН-ийн нэрлэсэн дүнтэй свопын гэрээ байгуулсан. Дээр дурдсанчлан, үүнийг тогтмол хүүтэй, 40ТН-ийн хөрөнгийн бодит үнэ цэнийн хейж эсвэл хувьсах хүүтэй, 40 ТН-ийн өр төлбөрийн мөнгөн гүйлгээний хейж гэж үзэж, сонгож болох юм.

**Асуудал (б) - Хүүний түвшний эрсдлийг цэвэр дүнгээр удирдан зохицуулахад ашигладаг үүсмэл хэрэглүүрийг нийт дүнгээр хийгдэх бодит үнэ цэнийн хейж эсвэл мөнгөн гүйлгээний хейжид хейжийн хэрэглүүр гэж сонгох эсэхийг шийдвэрлэхэд чухал анхаарах зүйлс нь юу байх вэ?**

Доор авч хэлэлцсэнчлэн, хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн буюу мөнгөн гүйлгээний өөрчлөлтөнд тухайн хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн буюу мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг тус тус харгалзуулах уг мэдээллийн системийн чадвар боломж болон урьдчилан төлөлтийн эрсдэлтэй үеийн хейжийн үр дүнтэй байдлын үнэлгээ нь гол чухал анхаарах зүйлсэд хамаардаг.

Бодит үнэ цэнийн хейжийн болон мөнгөн гүйлгээний хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангах шаардлагууд ба эдгээр ангиллуудын хейжийн олз, гарзын хүлээн зөвшөөрөлт нь ялгаатай учраас үүсмэл хэрэглүүрийг бодит үнэ цэнийн эрсдлийн эсвэл мөнгөн гүйлгээний эрсдлийн хейж гэж сонгох эсэх нь нягтлан бодох бүртгэлийн зорилгын хувьд чухал ач холбогдолтой байдаг.

*Урьдчилсан төлбөрийн үр нөлөө*

Олон санхүүгийн хэрэглүүрт угаасаа байдаг урьдчилсан төлбөрийн эрсдэл нь тухайн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ болон түүний мөнгөн гүйлгээний цаг хугацаанд нөлөө үзүүлэх бөгөөд бодит үнэ цэнийн хейжийн үр дүнтэй байдлын сорил ба мөнгөн гүйлгээний хейжийн өндөр магадлалын сорилд нөлөөлдөг.

Хейж хийж буй хэрэглүүр нь урьдчилсан төлбөрийн эрсдэлд өртдөг тохиолдолд мөнгөн гүйлгээний хейжтэй харьцуулахад бодит үнэ цэнийн хейжийн хувьд үр дүнтэй байдалд хүрэхэд ихэвчлэн илүү төвөгтэй байдаг. Бодит үнэ цэнийн хейжийн хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангахын тулд тухайн үүсмэл хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт нь тэрхүү хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нөхөхөд өндөр үр дүнтэй байхаар хүлээгдэж байх ёстой (УСНББОУС 29-ийн 98(б) параграф). Жишээлбэл; үүсмэл хейжийн хэрэглүүр нь тогтмол хугацаатай форвард гэрээ, харин хейж хийж буй санхүүгийн хөрөнгө нь зээлдэгч урьдчилан төлж болох эрсдэлд өртдөг бол энэхүү сорилыг хангахад төвөгтэй байж болох юм. Урьдчилан төлж болох эрсдэлд өртдөг, тогтмол хүүтэй хөрөнгүүдийн багцын хувьд, тухайн багц дахь бие даасан зүйл тус бүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт нь тэрхүү багцын хейж хийсэн эрсдэлд хамаарах бодит үнэ цэнийн ерөнхий өөрчлөлттэй ойролцоогоор хувь тэнцүүлсэн хамааралтай байна гэж дүгнэх нь мөн төвөгтэй байж болох юм. Хейж хийж буй эрсдэл нь бенчмарк хүүний түвшин, иймээс бодит үнэ цэнийн өөрчлөлт нь тухайн багц дахь зүйл нэг бүрийн хувьд хувь тэнцүүлсэн байна гэж дүгнэх боломжтой байлаа ч гэсэн хугацаа, купон, зээлийн төрөл болон бусад шинж чанаруудад үндэслэн тухайн хөрөнгийг ангилалуудад салган задлах шаардлагатай байж болох юм.

Эдийн засгийн утгаараа, урьдчилан төлж болох эрсдэлд өртдөг хөрөнгүүдэд хейж хийхийн тулд форвард үүсмэл хэрэглүүрийг ашиглаж болох боловч хүүний түвшин маш бага хэмжээгээр өөрчлөгддөг зөвхөн тийм тохиолдолд энэ нь үр дүнтэй байх юм. Хүүний түвшний тухайн нөхцлийн хувьд урьдчилсан төлбөрийн талаар ул үндэслэлтэй тооцооллыг хийх ба хүүний түвшний нөхцөл өөрчлөгдөхийн хэрээр уг үүсмэл төлөв байдалд тохируулга хийж болно. Байгууллагын эрсдлийн удирдлагын стратеги нь уг хейж хийсэн төлөв байдлын өөрчлөлтийг тусгахын тулд хейжийн хэрэглүүрийн дүнг үечлэн тохируулах явдал бол байгууллага нь хейжийн хэрэглүүрийн дүнг дараагийн удаа тохируулах хүртэлх зөвхөн тэр хугацаанд уг хейж өндөр үр дүнтэй байна гэдгийг батлан харуулах шаардлагатай. Гэвч энэ хугацаан дахь үр дүнтэй байдлын хүлээлт нь тэдгээр төлөв байдалд ирээдүйд хийх тохируулгыг харгалзаагүй хүүний түвшний өөрчлөлтийн боломж болон одоогийн бодит үнэ цэнийн эрсдэлд үндэслэсэн байх ёстой. Түүнчлэн, урьдчилан төлөх эрсдэлд хамааруулж болох бодит үнэ цэнийн эрсдэлд ихэвчлэн опционы тусламжтайгаар хейж хийдэг.

Мөнгөн гүйлгээний хейжийн хувьд хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангахын тулд урьдчилан таамагласан мөнгөн гүйлгээ, үүн дотроо мөнгөн орлогын гүйлгээний дахин хөрөнгө оруулалт эсвэл мөнгөн зарлагын гүйлгээний дахин санхүүжилт нь өндөр магадлалтай байх ёстой (УСНББОУС 29-ийн 98(в) параграф, мөн хейж нь уг хейжийн зүйл ба хейжийн хэрэглүүрийн мөнгөн гүйлгээний харилцан нөхөх өөрчлөлтүүдэд хүрэхэд өндөр үр дүнтэй байхаар хүлээгдэж байх (УСНББОУС 29-ийн 98(б) параграф)). Урьдчилсан төлбөр нь мөнгөн гүйлгээний

хугацаанд, ингэснээр уг урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдох магадлалд нөлөө үзүүлдэг. Хэрэв эрсдлийн удирдлагын зорилгоор хейжийг цэвэр дүнгээр тогтоодог бол байгууллага нь нийт мөнгөн гүйлгээний тодорхой хэсэгтэй холбоотой урьдчилан таамагласан ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлийн зорилгоор хейжийн зүйл гэж сонгохыг дэмжих нийт дүнгээрээ хангалттай хэмжээний тийм өндөр магадлалтай мөнгөн гүйлгээтэй байж болох юм. Энэ тохиолдолд хейж хийж буй гэж сонгосон нийт мөнгөн гүйлгээний тодорхой хэсгийг эрсдлийн удирдлагын зорилгоор хейж хийж байгаа цэвэр мөнгөн гүйлгээний дүнтэй тэнцүү байхаар сонгож болно.

### *Системийн анхаарах зүйлс*

Бодит үнэ цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэл нь мөнгөн гүйлгээний хейжийн нягтлан бодох бүртгэлээс өөр байдаг. Бодит үнэ цэнийн хейжтэй харьцуулахад мөнгөн гүйлгээний хейжийг хөөн шалгах ба удирдахын тулд одоо байгаа мэдээллийн системийг ашиглахад ихэвчлэн илүү хялбар байдаг.

Бодит үнэ цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэлийн дагуу хейж хийж буй гэж сонгосон хөрөнгө буюу өр төлбөрийг уг хейж хийж байгаа эрсдэлд хамаарах тэрхүү хейжийн хугацаан дахь бодит үнэ цэнийн тэдгээр өөрчлөлтийн хувьд дахин хэмжинэ. Ийм өөрчлөлт нь хейжийн зүйлийн дансны үнийг тохируулдаг бөгөөд хүүний мэдрэмжтэй хөрөнгө, өр төлбөрийн хувьд уг хейжийн зүйлийн үр ашигт хүүний түвшинд тохируулга хийхэд хүргэж болох юм (УСНББОУС 29-ийн 99-р параграф). Бодит үнэ цэнийн хейжийн ажиллагааны үр дүнд, үр ашигт хүүний түвшинг дахин тооцоолох, бодит үнэ цэнийн тохируулгыг хорогдуулж, дараагийн тайлант үед ашиг, алдагдалд тусгах дүнг тодорхойлох, тухайн хөрөнгийг борлуулах буюу өр төлбөрийг барагдуулах үед ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх дүнг тодорхойлох боломжийг уг байгууллагад олгохын тулд бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тэрхүү хейж хийж буй хөрөнгө, өр төлбөрт хуваарилах ёстой (УСНББОУС 29-ийн 99-р параграф ба УСНББОУС 29-ийн 103-р параграф). Бодит үнэ цэнийн хейжийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг даган мөрдөхийн тулд тухайн хейж хийж буй эрсдэлд хамааруулж болох бодит үнэ цэнийн өөрчлөлтүүдийг хөөн шалгах, тэдгээр өөрчлөлтийг бие даасан хейжийн зүйлтэй холбон уялдуулах, хейжийн зүйлийн үр ашигт хүүний түвшинг дахин тооцоолох, харгалзах хейжийн зүйлийн хугацааны туршид тэдгээр өөрчлөлтүүдийг ашиг, алдагдалд хуваарилан хорогдуулах тийм системийг ерөнхийдөө тогтоох шаардлагатай байдаг.

Мөнгөн гүйлгээний хейжийн хувьд, хейж хийж буй гэж сонгосон уг урьдчилан таамагласан ажил гүйлгээтэй холбоотой мөнгөн гүйлгээ нь хүүний түвшний өөрчлөлтийг тусгасан байдаг. Үүсмэл хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн хувьд хийгдэх тохируулгыг эхлээд цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрдөг (УСНББОУС 29-ийн 105-р параграф). Мөнгөн гүйлгээний хейжийн нягтлан бодох бүртгэлийн шаардлагуудыг даган мөрдөхийн тулд уг хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн улмаас цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн, хуримтлагдсан олз, гарзыг хэзээ ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх хэрэгтэй эсэхийг тодорхойлох шаардлагатай (УСНББОУС 29-ийн 111-р параграф ба УСНББОУС 29-ийн 112-р параграф). Мөнгөн гүйлгээний хейжийн хувьд, ийм тодорхойлолтыг бүрдүүлэх тусдаа систем бий болгох шаардлагагүй юм. Цэвэр

эрсдлийн хэмжээг тодорхойлоход ашигладаг систем нь тухайн үүсмэл хэрэглүүрийн мөнгөн гүйлгээний өөрчлөлт болон тэрхүү өөрчлөлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх хугацааны хуваарь гаргах суурь үндэслэлийг бүрдүүлдэг.

Хейж нь мөнгөн гүйлгээний өөрчлөлтийн эрсдэлтэй холбоотой тохиолдолд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх хугацааг урьдчилан тодорхойлж болно. Хейж хийж буй урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь ирээдүйн тодорхой тайлант үеүд дэх тухайн нэг үндсэн дүнтэй холбоотой байж болно. Ийм үндсэн дүн нь хүүний түвшний өөрчлөлтийн хувьд тус бүрдээ мөнгөн гүйлгээний эрсдэл үүсгэх хувьсах хүүтэй хөрөнгө ба дахин хөрөнгө оруулж буй мөнгөн орлогын гүйлгээ эсвэл хувьсах хүүтэй өр төлбөр ба дахин санхүүжүүлж буй мөнгөн зарлагын гүйлгээнээс бүрддэг. Ирээдүйн тодорхой тайлант үеүд дэх тухайн нэг үндсэн дүн нь үүсмэл хейжийн хэрэглүүрийн нэрлэсэн дүнтэй тэнцүү байх бөгөөд хүүний түвшний өөрчлөлтийн үр дүн болох мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг уг үүсмэл хейжийн хэрэглүүртэй уялдуулахын тулд үүсмэл хейжийн хэрэглүүрийн дахин үнэ тогтоолт буюу дуусгавар болох хугацаатай харгалзах зөвхөн тэрхүү тайлант үеийн хувьд түүнд хейж хийнэ. Цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн дүнг уг хейжийн зүйл нь ашиг, алдагдалд нөлөөлөх тухайн тайлант үед буюу үеүдэд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэж УСНББОУС 29-ийн 111-р параграфт тусгайлан заасан байдаг.

**Асуудал (в) –Хүүний түвшний өөрчлөлтийн үр дүн болох мөнгөн гүйлгээний өөрчлөлттэй холбоотойгоор хейжийн харилцааг мөнгөн гүйлгээний хейж гэж сонгосон бол УСНББОУС 29-ийн 98(а) параграфтаар шаардсан баримтжуулалтанд юуг тусган оруулах вэ?**

Уг баримтжуулалтанд дараах зүйлсийг тусган оруулна.

Хейжийн харилцаа – Мөнгөн гүйлгээний уялдаагүй байдлын эрсдлийг цэвэр дүнгээр тодорхойлохын тулд эрсдлийн удирдлагын зорилгоор ашигладаг мөнгөн гүйлгээний дуусгавар болох хугацааны хуваарь нь хейжийн харилцааны баримтжуулалтын нэгэн хэсэг болно.

Байгууллагын эрсдлийн удирдлагын зорилго ба хейж хийх стратеги – Байгууллагын ерөнхий эрсдлийн удирдлагын зорилго ба хүүний түвшний эрсдэлд хейж хийх стратеги нь хейжийн зорилго ба стратегийн баримтжуулалтын нэгэн хэсэг болно.

Хейжийн төрөл – Уг хейжийг мөнгөн гүйлгээний хейж гэж баримтжуулна.

Хейжийн зүйл – Тусгайлан заасан ирээдүйн тайлант үед гарч тохиолдохоор өндөр магадлалтай хүлээгдэж буй, тухайлбал сар бүрээр хуваарь гаргасан урьдчилан таамагласан ажил гүйлгээний бүлэг (хүүний мөнгөн гүйлгээ) байдлаар хейжийн зүйлийг баримтжуулна. Мөнгөн орлогын гүйлгээний дахин хөрөнгө оруулалт, үүн дотроо хөрөнгийн хүүний түвшинг дахин тогтоолтын үр дүн болох хүүний мөнгөн гүйлгээ эсвэл мөнгөн зарлагын гүйлгээний дахин санхүүжилт, үүн дотроо өр төлбөрийн хүүний түвшинг дахин тогтоолт болон санхүүгийн өр төлбөрийг дараагийн тайлант үед шилжүүлэлтийн үр дүн болох хүүний мөнгөн гүйлгээ нь хейжийн зүйлд хамаарч болох юм. Асуудал (д)-д авч хэлэлцсэнчлэн, нийт дүнгээр хейж хийж буй гэж сонгосон дүнгүүдийг тусган агуулахын тулд ирээдүйн тодорхой

тайлант үеүдэд өндөр магадлалтай, хангалттай түвшний мөнгөн гүйлгээ байгаа бол уг урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь магадлалын сорилыг хангана.

Хейж хийсэн эрсдэл – Хейж хийж буй гэж сонгосон эрсдлийг тухайн бүлгийн бүх зүйлсэд нийтлэг байх тодорхой зах зээлийн хүүний түвшний, ихэвчлэн эрсдэлгүй хүүний түвшний буюу банк хоорондын санал болгосон хүүний түвшний өөрчлөлтийн ерөнхий эрсдлийн нэг хэсэг байдлаар баримтжуулдаг. Хейжийн үр дүнтэй байдлын сорил нь тухайн хейжийн эхэнд болон дараагийн тайлант үеүдэд биелэгдэнэ гэдгийг ханган магадлахад туслахын тулд уг сонгосон хейж хийж буй хүүний түвшний эрсдлийн хэсгийг тэрхүү үүсмэл хейжийн хэрэглүүрийн өгөөжийн муруйтай ижил өгөөжийн муруйд үндэслэн баримтжуулж болно.

Хейжийн хэрэглүүр – Хейж хийж буй гэж сонгосон ирээдүйн тодорхой тайлант үеүдэд гарч тохиолдох уг урьдчилан таамагласан ажил гүйлгээтэй уялдах тэдгээр ирээдүйн тодорхой тайлант үеүд дэх тусгайлан заасан дүнгүүдийн хейж байдлаар үүсмэл хейжийн хэрэглүүр нэг бүрийг баримтжуулна.

Үр дүнтэй байдлыг үнэлэх арга – Үүсмэл хэрэглүүрүүдийг хейж гэж сонгосон холбогдох тайлант үеүдэд хуваарилсан түүний мөнгөн гүйлгээний өөрчлөлтүүдийг тухайн хейж хийж буй урьдчилан таамагласан ажил гүйлгээний мөнгөн гүйлгээний өөрчлөлтүүдтэй харьцуулснаар хэмжиж, уг үр дүнтэй байдлын сорилыг баримтжуулна. Мөнгөн гүйлгээний өөрчлөлтийн хэмжилт нь тэдгэр үүсмэл хэрэглүүрүүд болон хейжийн зүйлсийн холбогдох өгөөжийн муруйд үндэслэдэг.

**Асуудал (г) – Хэрэв хейжийн харилцааг мөнгөн гүйлгээний хейж гэж сонгосон бол байгууллага нь харилцан нөхөх өөрчлөлтөнд хүрэх өндөр үр дүнтэй хүлээлтийн талаархи УСНББОУС 29-ийн 98(б) параграфт заасан шаардлагыг хэрхэн ханган биелүүлэх вэ?**

Байгууллага нь хейж хийж буй гэж сонгосон хүүний түвшний эрсдэл ба тухайн хейжийн хэрэглүүрийн хүүний түвшний эрсдэл хоорондох түүхэн өндөр дүнтэй болон хүлээгдэж буй ирээдүйн корреляцийн хамаарлыг харуулсан шинжилгээ хийснээр өндөр үр дүнтэй байдлын хүлээлтийг батлан харуулж болно. Үүсмэл гэрээг байгуулахад ашигласан хейжийн харьцааны одоогийн баримтжуулалт нь үр дүнтэй байдлын хүлээлтийг батлан харуулах зорилгыг бас хангаж болох юм.

**Асуудал (д) – Хэрэв хейжийн харилцааг мөнгөн гүйлгээний хейж гэж сонгосон бол байгууллага нь УСНББОУС 29-ийн 98(в) параграфтаар шаардсанчлан, уг урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдох өндөр магадлалтай гэдгийг хэрхэн батлан харуулах вэ?**

Байгууллага нь хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний нэгтгэн нийлүүлсэн хангалттай түвшин байгаа гэдгийг харуулсан, мөнгөн гүйлгээний дуусгавар болох хугацааны хуваарийг бэлтгэх замаар үүнийг хийж болно. Хейж хийж буй гэж сонгосон уг урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь гарч тохиолдох өндөр магадлалтай гэдгийг тогтоохын тулд хөрөнгө, өр төлбөрийн хүүний түвшинг дахин тогтоосны үр нөлөөг энэхүү хуваарьт тусган харуулна. Ийм хуваарь нь удирдлагын тогтоосон санаа зорилго болон мөнгөн орлогын гүйлгээгээр дахин хөрөнгө оруулалт хийх ба мөнгөн зарлагын гүйлгээг дахин санхүүжүүлэх өмнөх практикаар дэмжигдсэн байвал зохино.

Жишээлбэл; байгууллага нь ойрын ирээдүйн тодорхой хугацаанд уг нэгтгэн нийлүүлсэн нийт мөнгөн орлогын гүйлгээ 100 ТН, нэгтгэн нийлүүлсэн нийт мөнгөн зарлагын гүйлгээ 90 ТН гэж урьдчилан таамаглаж болох юм. Энэ тохиолдолд байгууллага нь нийт 10 ТН-ийн мөнгөн орлогын гүйлгээний урьдчилан таамагласан дахин хөрөнгө оруулалтыг ирээдүйн хугацаанд хейжийн зүйл гэж сонгохыг хүсэж болно. Хэрэв 10 ТН-ээс илүү урьдчилан таамагласан мөнгөн орлогын гүйлгээг гэрээгээр тусгайлан заасан бөгөөд энэ нь зээлийн эрсдэл багатай бол байгууллага нь нийт 10 ТН-ийн мөнгөн орлогын гүйлгээ гарч тохиолдох өндөр магадлалтай гэсэн батламж мэдэгдлийг дэмжих, мөн дахин хөрөнгө оруулалт хийх хугацааны тодорхой хэсгийн хувьд тэдгээр мөнгөн гүйлгээний урьдчилан таамагласан дахин хөрөнгө оруулалтыг хейж хийж буй гэж сонгохыг дэмжих хүчтэй нотолгоотой болно. Урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдох өндөр магадлалтай гэдгийг бусад нөхцлийн дагуу бас батлан харуулж болох юм.

**Асуудал (е) – Хэрэв хейжийн харилцааг мөнгөн гүйлгээний хейж гэж сонгосон бол байгууллага нь үр дүнтэй байдлыг УСНББОУС 29-ийн 98(г) параграф болон УСНББОУС 29-ийн 98(д) параграфын дагуу хэрхэн үнэлж, хэмжих вэ?**

Үр дүнтэй байдлыг хамгийн наад зах нь байгууллага өөрийн жилийн буюу завсрын хугацааны санхүүгийн тайланг бэлтгэх үедээ хэмжих шаардлагатай. Гэвч байгууллага нь үр дүнтэй байдлыг тусгайлан заасан үечилсэн хугацаанд, сар бүрийн буюу бусад холбогдох тайлант үеийн эцэст байнга хэмжихийг хүсэж болох юм. Мөн хейжийн хэрэглүүр гэж сонгосон үүсмэл төлөв байдал өөрчлөгдсөн эсвэл хейжийг дуусгавар болгосон аливаа тохиолдолд хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх болон мөнгөн гүйлгээний хейж гэж сонгосон үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөх нь тохиромжтой гэдгийг ханган магадлахын тулд үр дүнтэй байдлыг хэмжинэ.

Үүсмэл хэрэглүүрийн мөнгөн гүйлгээний өөрчлөлтийг тооцоолж, түүнийг хейж гэж сонгосон холбогдох тайлат үеүдэд хуваарилах бөгөөд уг урьдчилан таамагласан ажил гүйлгээний мөнгөн гүйлгээний өөрчлөлтийн тооцоололтой харьцуулна. Хейжийн зүйлд хамаарах өгөөжийн муруй, үүсмэл хейжийн хэрэглүүр болон хейж хийж буй тухайн тайлант үеийн харгалзах хүүний түвшинд үндэслэн тооцооллыг хийдэг.

Үр дүнтэй байдлыг тодорхойлоход ашигласан хуваарь баримтлах бөгөөд цэвэр хөрөнгө/өмчид анх хүлээн зөвшөөрсөн хейжийн олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх тайлант үеийг тодорхойлоход суурь болгон түүнийг ашиглана.

**Асуудал (ж) – Хэрэв хейжийн харилцааг мөнгөн гүйлгээний хейж гэж сонгосон бол байгууллага нь уг хейжийг хэрхэн тайлагнах вэ?**

Хейжийг УСНББОУС 29-ийн 106-р параграфас УСНББОУС 29-ийн 111-р параграфт заасан нөхцлүүдийн дагуу дараах байдлаар мөнгөн гүйлгээний хейж гэж тайлагнана:

- (а) Үр дүнтэй хейжээс үүснэ гэж тодорхойлсон хейжийн хэрэглүүрийн олз, гарзын хэсгийг уг үр дүнтэй байдлыг хэмжих аливаа тохиолдолд цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрөх; ба
- (б) Хейжийн хэрэглүүрээс үүссэн олз, гарзын үр дүнгүй хэсгийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх.

Цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн дүнг тухайн хейжийн зүйл нь ашиг, алдагдалд нөлөөлөх тэрхүү тайлант үед буюу үеүдэд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх хэрэгтэй гэж УСНББОУС 29-ийн 111-р параграфт заасан байдаг. Иймээс урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдсон үед өмнө нь цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрч байсан дүнгүүдийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Жишээлбэл; хэрэв хүүний түвшний свопыг уг урьдчилан таамагласан цуврал мөнгөн гүйлгээний хейжийн хэрэглүүр гэж сонгосон бол тухайн свопын мөнгөн гүйлгээний өөрчлөлтүүдийг цэвэр хөрөнгө/өмчөөс хасаж, тэрхүү урьдчилан таамагласан мөнгөн гүйлгээ ба свопын мөнгөн гүйлгээ нь бие биенийгээ харилцан нөхөх тайлант үеүдэд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

**Асуудал (и) – Хэрэв хейжийн харилцааг мөнгөн гүйлгээний хейж гэж сонгосон бол тухайн хейжийн хэрэглүүрийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосон, хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуур цаашид хангагдахаа больсон эсвэл хейж хийсэн уг урьдчилан таамагласан ажил гүйлгээ цаашид гарч тохиолдохоор хүлээгдэхээ больсон үед цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрч байсан аливаа хуримтлагдсан олз, гарзыг хэрхэн тайлагнах вэ?**

Хэрэв хейжийн хэрэглүүрийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосон эсвэл хейж нь хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг цаашид хангахаа больсон, жишээлбэл урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь цаашид өндөр магадлалтай байхаа больсон бол цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрч байсан аливаа хуримтлагдсан олз, гарз нь уг урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдох хүртэл цэвэр хөрөнгө/өмчид хэвээр байна (УСНББОУС 29-ийн 112(а) параграф ба УСНББОУС 29-ийн 112(б) параграф). Хэрэв хейж хийсэн урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь цаашид гарч тохиолдохоор хүлээгдэхээ больсон бол хуримтлагдсан цэвэр олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө (УСНББОУС 29-ийн 112(в) параграф).

**Асуудал (к) – Хейжийн хэрэглүүр эргэлтэнд байх үед хейжийн харилцааг зөвхөн түүний цаг хугацаанд хамаарах хэсгийн хувьд сонгож болохгүй гэж УСНББОУС 29-ийн 84-р параграфт заасан. Хэрэв хейжийн харилцааг мөнгөн гүйлгээний хейж гэж сонгосон ба уг хейж нь өндөр үр дүнтэй байх сорилыг дараагийн тайлант үед хангахаа больсон бол тухайн хейжийн хэрэглүүрийг дахин сонгохыг УСНББОУС 29-ийн 84-р параграфтаар хориглодог уу?**

Үгүй. Үүсмэл хэрэглүүрийг түүний дуусгавар болох хугацааны зөвхөн үлдсэн хэсгийн хувьд хейжийн хэрэглүүр гэж сонгож болохгүй гэж УСНББОУС 29-ийн 84-р параграфт заасан. УСНББОУС 29-ийн 84-р параграф нь үүсмэл хэрэглүүрийн дуусгавар болох анхны хугацааг заадаггүй. Хэрэв хейжийн үр дүнтэй байдал хангагдахгүй бол уг үүсмэл хэрэглүүрийн олз, гарзын үр дүнгүй хэсгийг ашиг, алдагдалд нэн даруй хүлээн зөвшөөрөх (УСНББОУС 29-ийн 106-р параграф)

бөгөөд хейжийн харилцааны өмнөх сонголтонд үндэслэсэн хейжийн нягтлан бодох бүртгэлийг цаашид үргэлжлүүлж болохгүй (УСНББОУС 29-ийн 112-р параграф). Ийм тохиолдолд хэрэв уг хейжийн харилцаа нь шаардлагатай нөхцлүүдийг хангаж байвал тухайн үүсмэл хэрэглүүрийг тэрхүү шинэ хейжийн харилцаанд хейжийн хэрэглүүр гэж ирээдүйд дахин сонгож болно. Үүсмэл хэрэглүүрийг түүний эргэлтэнд байх нийт хугацааны туршид хейж гэж дахин сонгох ёстой.

**Асуудал (л) – Мөнгөн гүйлгээний хейжийн хувьд, хүүний түвшний эрсдлийг цэвэр дүнгээр удирдан зохицуулахын тулд үүсмэл хэрэглүүрийг ашигладаг бөгөөд тэрхүү үүсмэл хэрэглүүрийг уг урьдчилан таамагласан хүүний мөнгөн гүйлгээ буюу түүний хэсгүүдийн мөнгөн гүйлгээний хейж гэж нийт дүнгээр сонгодог бол хейж хийсэн урьдчилан таамагласан ажил гүйлгээний гарч тохиолдолт нь цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрч байсан хейжийн олү, гарзын хэсгийг цэвэр хөрөнгө/өмчид хэвээр үлдээхэд хүргэх хөрөнгө, өр төлбөр үүсгэх үү?**

Үгүй. Дээрх Асуудал (в)-д дурдсан хейжийн харилцааны хувьд, хейжийн зүйл нь ирээдүйн тодорхой тайлант үеүд дэх хүүний мөнгөн гүйлгээнүүдээс бүрдэх урьдчилан таамагласан ажил гүйлгээнүүдийн бүлэг байна. Хейж хийсэн урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхөд хүргэхгүй бөгөөд хейж хийж буй гэж сонгосон хүүний түвшний өөрчлөлтийн үр нөлөөг тухайн урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдсон тайлант үед ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Хэдийгээр энэ нь энд дурдсан хейжийн төрлүүдэд хамааралгүй боловч үүсмэл хэрэглүүрийг уг санхүүгийн хөрөнгийн урьдчилан таамагласан худалдан авалт эсвэл санхүүгийн өр төлбөрийн урьдчилан таамагласан гаргалтын хувьд хейж гэж сонгохын оронд цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрч байсан холбогдох олз, гарзыг тэрхүү хейж хийсэн урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь ашиг, алдагдалд нөлөөлөх тухайн тайлант үеийн буюу үеүдийн (хүүний зардлыг хүлээн зөвшөөрсөн тайлант үеүд гэх мэт) ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Гэвч байгууллага нь цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн бүх буюу зарим цэвэр алдагдлыг ирээдүйн нэг буюу хэд хэдэн тайлант үеүдэд нөхөхгүй гэж үзэж байгаа бол тухайн байгууллага нь нөхөгдөхгүй гэж үзэж буй дүнг ашиг, алдагдалд нэн даруй дахин ангилна.

**Асуудал (м) – Дээрх Асуудал (в)-гийн хариултанд тухайн сонгосон хейжийн зүйл нь мөнгөн гүйлгээний эрсдлийн хэсэг байна гэж заасан. УСНББОУС 29 нь мөнгөн гүйлгээний эрсдлийн хэсгийг хейжийн зүйл гэж сонгохыг зөвшөөрдөг үү?**

Тийм. УСНББОУС 29 нь урьдчилан таамагласан ажил гүйлгээний мөнгөн гүйлгээний эрсдлийн хэсгийн хейжийг тусгайлан авч үздэггүй. Гэвч үр дүнтэй байдлыг нь хэмжиж чадах түүний мөнгөн гүйлгээний эсвэл бодит үнэ цэнийн зөвхөн тэрхүү хэсэгтэй холбоотой эрсдлийн хувьд уг санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр нь хейжийн зүйл байж болно гэж УСНББОУС 29-ийн 90-р параграфт заасан. Хөрөнгө, өр төлбөрийн хүүний түвшинг дахин тогтоосоны үр дүн болох мөнгөн гүйлгээний эрсдлийн хэсэгт хейж хийх чадвар, боломжтой байдал нь мөнгөн орлогын гүйлгээгээр хийх урьдчилан таамагласан дахин хөрөнгө оруулалт эсвэл санхүүгийн өр төлбөрийн урьдчилан таамагласан дахин санхүүжилт буюу дараагийн тайлант үед шилжүүлэлтээс үүсэх мөнгөн гүйлгээний эрсдлийн хэсэгт



бас хейж хийж болно гэдгийг илэрхийлнэ. Эрсдлийн хэсгийн хувьд хейжийн зүйл болох шалгуурыг хангах суурь үндэслэл нь түүний үр дүнтэй байдлыг хэмжих чадвар боломж юм. Тодорхой эрсдлүүдэд хамааруулж болох түүний мөнгөн гүйлгээний эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлтийн холбогдох хэсгийг салган тусгаарлах ба хэмжих хүндрэлтэй байдлын улмаас тухайн санхүүгийн бус хөрөнгө буюу санхүүгийн бус өр төлбөр нь гадаад валютын эрсдлийн хувьд бүхэлд нь, буюу түүний зарим хэсгийн хувьд, харин бусад эрсдлийн хувьд түүний хэсгийн хувьд биш, харин зөвхөн бүхэлд нь хейжийн зүйл байж болно гэж тусгайлан заасан УСНББОУС 29-ийн 92-р параграфтаар үүнийг цаашид дэмжин илэрхийлнэ. Иймээс үр дүнтэй байдлыг хэмжиж чадна гэж үзвэл тухайлбал, хувьсах хүүтэй хөрөнгө буюу өр төлбөрийн хүүний түвшинг дахин тогтоосонтой холбоотой уг урьдчилан таамагласан ажил гүйлгээний мөнгөн гүйлгээний эрсдлийн хэсгийг хейжийн зүйл гэж сонгож болно.

**Асуудал (н) – Дээрх Асуудал (в)-гийн хариултанд, хейжийн зүйлийг урьдчилан таамагласан ажил гүйлгээнүүдийн бүлэг байдлаар баримтжуулна гэж заасан. Эдгээр ажил гүйлгээ нь анх гарч тохиолдох үеийн нөхцлүүдээс, үүн дотроо зээлийн эрсдэл, дуусгавар болох хугацаа, опционы шинжүүдийн хувьд өөр учраас тухайн хейж хийсэн бүлэг нь эрсдлийн ижил төсөөтэй шинж чанаруудтай байхыг шаарддаг УСНББОУС 29-ийн 87-р параграф болон УСНББОУС 29-ийн 93-р параграфт заасан сорилыг уг байгууллага хэрхэн хангах вэ?**

Ижил төсөөтэй эрсдлийн шинж чанар бүхий хөрөнгө, өр төлбөр, арилжааны баталгаа, урьдчилан таамагласан ажил гүйлгээний бүлэгт хейж хийхээр УСНББОУС 29-ийн 87-р параграфт заасан. УСНББОУС 29-ийн 93-р параграф нь нэмэлт заавар удирдамжаар хангадаг бөгөөд хоёр нөхцөл хангагдаж байвал бүлгээр хейж хийхийг зөвшөөрнө гэж заасан. Тэрхүү хоёр нөхцөл нь: тухайн бүлэг дэх бие даасан зүйлс нь хейж хийгдэж буй гэж сонгосон уг эрсдлийг хуваалцдаг байх; бүлэг дэх бие даасан зүйл тус бүрийн хувьд хейж хийсэн эрсдэлд хамааруулж болох бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бодит үнэ цэнийн нийт өөрчлөлттэй ойролцоогоор шууд хамааралтай байхаар хүлээгдэж байх.

Байгууллага нь үүсмэл хейжийн хэрэглүүрийг нийт эрсдэлтэй уялдуулан холбох тохиолдолд хейжийн зүйл нь үндсэндээ урьдчилан таамагласан ажил гүйлгээнүүдийн бүлэг байна. Урьдчилан таамагласан ажил гүйлгээнүүдийн бүлэгтэй холбоотой мөнгөн гүйлгээний эрсдлийн хейжийн хувьд, дахин үнэ тогтоох уг урьдчилан таамагласан ажил гүйлгээ, хөрөнгө, өр төлбөрийн нийт эрсдэл нь ихээхэн өөр эрсдэл байж болох юм. Урьдчилан таамагласан ажил гүйлгээнээс үүсэх эрсдэл нь зээлийн эрсдэл, дуусгавар болох хугацаа, опцион ба бусад шинжүүдтэй холбоотойгоор хүлээгдэж буй нөхцлүүдээс хамааран өөр байж болно. Хэдийгээр нийт эрсдэл нь тухайн бүлэг дэх бие даасан зүйлсийн хувьд өөр байж болох боловч тэрхүү бүлгийн зүйл тус бүрд угаасаа байдаг тодорхой эрсдлийг түүнд хейж хийж буй гэж сонгож болно.

Бүлэг дэх зүйлс нь хейж хийгдэж буй гэж тэдгээрийг сонгосон тухайн нэг эрсдлийг хуваалцдаг бол тэдгээр зүйлс нь уг эрсдэлтэй заавал ижил нийт эрсдэлтэй байх албагүй юм. Санхүүгийн хэрэглүүрүүдийн багцын ихэвчлэн хамтран хуваалцдаг нийтлэг эрсдэл нь эрсдэлгүй буюу бенчмарк хүүний түвшний өөрчлөлтийн эрсдэл

эсвэл тухайн багц дахь хамгийн өндөр зээлийн зэрэглэлтэй хэрэглүүрийн (өөрөөр хэлбэл, хамгийн бага зээлийн эрсдэлтэй хэрэглүүрийн) эрсдэлтэй тэнцүү байх тийм зээлийн эрсдэл бүхий тусгайлан заасан хүүний түвшний өөрчлөлтийн эрсдэл байна. Нэг багцад бүлэглэн оруулсан хэрэглүүрүүд нь зээлийн өөр өөр эрсдэлтэй бол эрсдлийн тэрхүү хэсгийн хувьд тэдгээрт бүлэг байдлаар хейж хийж болно. Хейж хийж буй гэж сонгосон зүйлсийн хувьд нийтлэг байх эрсдэл нь тухайн багц дахь хамгийн өндөр зээлийн зэрэглэлтэй хэрэглүүрээс үүсэх хүүний түвшний өөрчлөлтийн эрсдэл байна. Энэ нь тухайн бүлэг дэх бие даасан зүйл тус бүрийн хувьд хейж хийсэн эрсдэлд хамааруулж болох бодит үнэ цэнийн өөрчлөлт нь тухайн бүлгийн хувьд хейж хийсэн эрсдэлтэй холбоотой бодит үнэ цэнийн нийт өөрчлөлттэй ойролцоогоор шууд хамааралтай байна гэдгийг ханган магадалдаг. Хейжийн харилцааг тухайн хейжийн хэрэглүүрийн хувьд бүхэлд нь сонгодог учраас хейжийн хэрэглүүр нь уг хейж хийж буй хамгийн өндөр зээлийн зэрэглэлтэй хэрэглүүрийн зээлийн чанараас муу зээлийн чанартай бол зарим үр дүнгүй байдал үүсэх магадлалтай байдаг (УСНББОУС 29-ийн 83-р параграф). Жишээлбэл; хөрөнгүүдийн багц нь А, ВВ, В зэрэглэлтэй хөрөнгүүдээс бүрддэг бөгөөд тэдгээр хөрөнгийн одоогийн зах зээлийн хүүний түвшин нь харгалзан ЛАЙБОР+20 суурь оноо, ЛАЙБОР+40 суурь оноо, ЛАЙБОР+60 суурь оноо бол байгууллага нь хувьсах хүүний түвшний эрсдэлд хейж хийхийн тулд тогтмол хүү-төлөх ба ЛАЙБОР-т үндэслэсэн хувьсах хүү хүлээн авах свопыг ашиглаж болно. Хейж хийж буй эрсдэл гэж ЛАЙБОР-ыг сонгосон бол уг хейжийн зүйлийн ЛАЙБОР-оос давсан зээлийн тархалтыг тухайн сонгосон хейжийн харилцаа болон хейжийн үр дүнтэй байдлын үнэлгээнд оруулахгүй хасна.

### **Е.6.3 Асуулт Е.6.2-д дурдсан хандлагыг хэрэглэх үлгэрчилсэн жишээ**

**Энэхүү жишээний зорилго нь хейжийн төлөв байдлыг тогтоох, хянан үнэлэх, тохируулах үйл явц, түүнчлэн байгууллага нь өөрийн хүүний түвшний эрсдлийг нийт байгууллагын хэмжээнд удирдан зохицуулдаг тохиолдолд Асуулт Е.6.2-д дурдсан, хейжийн нягтлан бодох бүртгэлд уг хандлагыг хэрэглэхдээ мөнгөн гүйлгээний хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангах үйл явцыг үлгэрчлэн харуулах явдал юм. Энэ утгаараа, уг жишээ нь хейжийн нягтлан бодох бүртгэлийг ашиглах боломж олгох ба одоо байгаа эрсдлийн удирдлагын системд шаардлагагүй өөрчлөлт оруулахаас зайлсхийх, хэрэгцээгүй бүртгэл хөтлөх ба хөөн шалгалт хийхээс зайлсхийхийн тулд тэрхүү системийн давуу талуудыг ашиглах арга зүйг тодорхойлно.**

Энд үлгэрчлэн харуулсан арга хандлага нь ашиглаж болох ба хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангах эрсдлийн удирдлагын олон процессоос зөвхөн нэгийг тусган илэрхийлнэ. Энэхүү хандлагыг ашиглаж буй нь бусад хувилбаруудыг ашиглаж болохгүй буюу ашиглах хэрэггүй гэсэн үг биш юм. Уг үлгэрчлэн харуулсан арга хандлагыг бусад нөхцөл байдалд (мөнгөн гүйлгээний хейж гэх мэт), жишээлбэл, арилжааны бичгийн санхүүжилтийн дараагийн тайлант үед шилжүүлэлтийн хейжид бас ашиглаж болно.

*Мөнгөн гүйлгээний эрсдлийг тодорхойлох, үнэлэх ба бууруулах*

Дараах хэлэлцүүлэг ба үлгэрчилсэн жишээ нь тодорхой валютаар хүлээгдэж буй мөнгөн гүйлгээ нийт байгууллагын хэмжээнд задлан шинжилснээр өөрийн хүүний түвшний эрсдлийг удирдан зохицуулдаг Сангийн яам гэх мэт байгууллагн эрсдлийн удирдлагын үйл ажиллагаанд голлон чиглэнэ. Уг мөнгөн гүйлгээний шинжилгээ нь тухайн байгууллагын хүүний түвшний эрсдлийг тогтоох, тэрхүү эрсдлийг удирдахын тулд хейжийн ажил гүйлгээ хийх, эрсдлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг үнэлэх, мөнгөн гүйлгээний хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангах ба түүнийг хэрэглэх суурь үндэслэлийг бүрдүүлнэ.

Доорх үлгэрчилсэн жишээнд байгууллага нь Тайлант үе Х0-ын эхэнд дараах хүлээгдэж буй ирээдүйн цэвэр мөнгөн гүйлгээтэй, тухайн валютаар эргэлтэнд буй бөгөөд хүүний түвшний свопоос бүрдэх хейжийн төлөв байдалтай гэж үзсэн. Доор харуулсан мөнгөн гүйлгээ нь тухайн тайлант үеийн эцэст гарч тохиолдохоор хүлээгдэж байгаа, иймээс мөнгөн орлогын гүйлгээгээр хийх дахин хөрөнгө оруулалт буюу дахин үнэ тогтоолт, эсвэл мөнгөн зарлагын гүйлгээний дахин санхүүжилт буюу дахин үнэ тогтоолтын үр дүнд дараагийн тайлант үед мөнгөн гүйлгээний хүүний эрсдэл үүснэ.

Байгууллага нь хүүний түвшний эрсдлийн байнгын удирдлагын хөтөлбөртэй гэж уг жишээнд үзсэн. Тайлант үе Х0-ын эхэнд оршин байсан хейжийн төлөв байдал ба хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг Хуваарь I-д харуулсан. Шинжилгээний эхлэлийн цэгийг бүрдүүлэхийн тулд үүнийг энд тусган харуулсан. Энэ нь Тайлант үе Х1-ийн эхэнд хийгдэх үнэлгээтэй холбоотойгоор одоо байгаа хейжийг харгалзан үзэх суурь үндэслэл болно.

<b>Хуваарь I Тайлант үеийн эцэс: Хүлээгдэж буй мөнгөн гүйлгээ ба хейжийн төлөв байдал</b>							
<i>Улирлын тайлант үе</i>	<i>X0</i>	<i>X1</i>	<i>X2</i>	<i>X3</i>	<i>X4</i>	<i>X5</i>	<i>...n</i>
<i>(Нээж)</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>
Хүлээгдэж буй цэвэр мөнгөн гүйлгээ		1,100	1,500	1,200	1,400	1,500	х,xxx
<i>Эргэлтэнд буй хүүний түвшний своп:</i>							
Тогтмол хүү хүлээн авах ба хувьсах хүү төлөх (нэрлэсэн дүн)	2,000	2,000	2,000	1,200	1,200	1,200	х,xxx
Тогтмол хүү төлөх ба хувьсах хүү хүлээн авах (нэрлэсэн дүн)	(1,000)	(1,000)	(1,000)	(500)	(500)	(500)	х,xxx
Эргэлтэнд буй свопын дараах цэвэр эрсдэл		100	500	500	700	800	х,xxx

Уг хуваарьт таван улирлын тайлант үеийг харуулсан. Бодит шинжилгээ нь олон жилийн тайлант үед үргэлжлэх бөгөөд "...n" гэсэн тэмдэглэгээгээр илэрхийлсэн. Өөрийн хүүний түвшний эрсдлийг нийт байгууллагын хэмжээнд удирдан зохицуулдаг байгууллага нь мөнгөн гүйлгээний эрсдлээ үечлэн дахин үнэлнэ. Үнэлгээний давтамж нь тухайн байгууллагын эрсдлийн удирдлагын бодлогоос хамаардаг.

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

Энэхүү үлгэрчилсэн жишээний хувьд, байгууллага нь өөрийн мөнгөн гүйлгээний эрсдлийг Тайлант үе Х0-ын эцэст дахин үнэлж байна. Үнэлгээний үйл явцын эхний алхам нь одоо байгаа хүү олдог хөрөнгө ба хүү төлдөг өр төлбөр, үүн дотроо богино хугацаат хөрөнгийн болон богино хугацаат өр төлбөрийн дараагийн тайлант үед шилжүүлэлтээс үүсэх урьдчилан таамагласан цэвэр мөнгөн гүйлгээний эрсдлийг тогтоох явдал юм. Цэвэр мөнгөн гүйлгээний эрсдлийн урьдчилсан таамаглалыг доорх Хуваарь II-д үлгэрчлэн харуулсан. Эрсдлийн удирдлагын зорилгоор хүүний түвшний эрсдлийг үнэлэх нийтлэг арга зүй нь хугацааны өөр өөр мужууд дахь хүүний түвшний мэдрэмжтэй хөрөнгө ба хүүний түвшний мэдрэмжтэй өр төлбөрийн хоорондох зөрүүг харуулсан хүүний түвшний мэдрэмжийн зөрүүгийн шинжилгээ юм. Хейжийн нягтлан бодох бүртгэлийн зорилгоор хүүний түвшний эрсдэлд өртөх мөнгөн гүйлгээний эрсдлийг тодорхойлох эхлэлийн цэг болгон ийм шинжилгээг ашиглаж болно.

<b>Хуваарь II Урьдчилан таамагласан цэвэр мөнгөн гүйлгээ ба дахин үнэ тогтоолтын эрсдэл</b>							
<i>Улирлын тайлант үе (Нэгж)</i>	<i>Лав</i>	<i>X1 ТН</i>	<i>X2 ТН</i>	<i>X3 ТН</i>	<i>X4 ТН</i>	<i>X5 ТН</i>	<i>...n ТН</i>
<b>МӨНГӨН ОРЛОГЫН ГҮЙЛГЭЭ БА ДАХИН ҮНЭ ТОГТООЛТЫН ЭРСДЭЛ-Хөрөнгүүдээс</b>							
<i>Үндсэн дүн ба хүүний төлбөрүүд:</i>							
Урт хугацаат тогтмол хүү	(1)	2,400	3,000	3,000	1,000	1,200	х,xxx
Богино хугацаат (дараагийн тайлант үед шилжүүлэлт)	(1) (2)	1,575	1,579	1,582	1,586	1,591	х,xxx
Хувьсах хүү – үндсэн дүнгийн төлбөр	(1)	2,000	1,000	-	500	500	х,xxx
Хувьсах хүү – тооцоолсон хүү	(2)	125	110	105	114	118	х,xxx
<b>Хүлээгдэж буй мөнгөн орлогын гүйлгээ</b>		<b>6,100</b>	<b>5,689</b>	<b>4,687</b>	<b>3,200</b>	<b>3,409</b>	<b>х,xxx</b>
Хувьсах хүүтэй хөрөнгийн үлдэгдэл	(3)	8,000	7,000	7,000	6,500	6,000	х,xxx
<b>Мөнгөн орлогын гүйлгээ ба дахин үнэ тогтоолт</b>	<b>(4)</b>	<b>14,100</b>	<b>12,689</b>	<b>11,687</b>	<b>9,700</b>	<b>9,409</b>	<b>х,xxx</b>
<b>МӨНГӨН ЗАРЛАГЫН ГҮЙЛГЭЭ БА ДАХИН ҮНЭ ТОГТООЛТЫН ЭРСДЭЛ-Өр төлбөрөөс</b>							
<i>Үндсэн дүн ба хүүний төлбөрүүд:</i>							
Урт хугацаат тогтмол хүү	(1)	2,100	400	500	500	301	х,xxx
Богино хугацаат (дараагийн тайлант үед шилжүүлэлт)	(1) (2)	735	737	738	740	742	х,xxx
Хувьсах хүү – үндсэн дүнгийн төлбөр	(1)	-	-	2,000	-	1,000	х,xxx
Хувьсах хүү – тооцоолсон хүү	(2)	100	110	120	98	109	х,xxx
<b>Хүлээгдэж буй мөнгөн зарлагын гүйлгээ</b>		<b>2,935</b>	<b>1,247</b>	<b>3,358</b>	<b>1,338</b>	<b>2,152</b>	<b>х,xxx</b>
Хувьсах хүүтэй өр төлбөрийн үлдэгдэл	(3)	8,000	8,000	6,000	6,000	5,000	х,xxx
<b>Мөнгөн зарлагын гүйлгээ ба дахин үнэ тогтоолт</b>	<b>(4)</b>	<b>10,935</b>	<b>9,247</b>	<b>9,358</b>	<b>7,338</b>	<b>7,152</b>	<b>х,xxx</b>
<b>ЦЭВЭР ЭРСДЭЛ</b>	<b>(5)</b>	<b>3,165</b>	<b>3,442</b>	<b>2,329</b>	<b>2,362</b>	<b>2,257</b>	<b>х,xxx</b>

**Хуваарь II Урьдчилан таамагласан цэвэр мөнгөн гүйлгээ ба дахин үнэ тогтоолтын эрсдэл**

1. Удирдлагын санаа зорилго болон зах зээлийн хүчин зүйлсэд үндэслэсэн таамаглалууд ба гэрээний нөхцлүүдийг ашиглан мөнгөн гүйлгээг тооцоолдог. Богино хугацаат хөрөнгө ба өр төлбөрийг дараагийн тайлант үеүдэд цаашид шилжүүлсээр байна гэж төсөөлнө. Урьдчилсан төлбөр, үл төлөлт, хадгаламжийн буцаан таталтын талаархи таамаглалууд нь зах зээлийн болон түүхэн мэдээнд үндэслэдэг. Үндсэн дүнгийн болон хүүний орлогын эсвэл зарлагын мөнгөн гүйлгээгээр тайлант үе бүрийн эцэст одоогийн зах зээлийн хүүний түвшнээр харгалзан дахин хөрөнгө оруулалт хийх буюу дахин санхүүжүүлэх бөгөөд тэдгээр нь өөрсдийн өртөх бенчмарк хүүний түвшний эрсдлийг хамтран хуваалцана гэж төсөөлдөг.
2. Хувьсах хүүтэй санхүүгийн хэрэглүүрүүдийн хүүний төлбөр, богино хугацаат хөрөнгө ба өр төлбөрийн хүлээгдэж буй дараагийн тайлант үеийн шилжүүлэлтийг урьдчилан таамаглахын тулд Хуваарь VI-д харуулсан, форвард хүүний түвшинг ашигласан. Урьдчилан таамагласан бүх мөнгөн гүйлгээ нь гарч тохиолдохоор хүлээгдэж буй хугацааны тодорхой үеүдтэй (3 сар, 6 сар, 9 сар, 12 сар) холбоотой байдаг. Үнэн хэрэгтээ зөвхөн цэвэр мөнгөн нэмэгдлээр дахин хөрөнгө оруулалт хийж болох боловч иж бүрэн тусгах үүднээс дахин хөрөнгө оруулалт, дахин санхүүжилт, дахин үнэ тогтоолтоос үүссэн хүүний мөнгөн гүйлгээг нийт дүнгээр уг хуваарьт тусгаж, харуулсан. Урьдчилан таамагласан хүүний мөнгөн гүйлгээг үйл ажиллагааны зардлыг нөхөхөд ашиглах ба аливаа үлдсэн дүн нь эрсдлийн удирдлагын шийдвэрт нөлөө үзүүлэхүйц хангалттай биш байж болох учраас зарим байгууллага нь ийм урьдчилан таамагласан хүүний мөнгөн гүйлгээг эрсдлийн удирдлагын зорилгын хувьд харгалзан үздэггүй.
3. Хувьсах хүүтэй хөрөнгө ба өр төлбөрийн үлдэгдлийг дахин үнэлэн тогтоох тайлант үе бүрд тэдгээр хувьсах хүүтэй хөрөнгө, өр төлбөрийн үлдэгдлийг харгалзан тусгахын тулд мөнгөн гүйлгээний урьдчилсан таамаглалыг өөрчлөн тохируулдаг. Ийм хөрөнгө, өр төлбөрийн үндсэн дүнг үнэн хэрэгтээ төлөхгүй учраас эдгээр нь мөнгөн гүйлгээ үүсгэхгүй. Харин хүүг тайлант үе бүрд одоогийн зах зээлийн хүүний түвшинд үндэслэн үндсэн дүнгээс тооцдог учраас үндсэн дүнгийн мөнгөн гүйлгээгээр дахин хөрөнгө оруулалт эсвэл дахин санхүүжилт хийсэнтэй адилаар тэдгээр үндсэн дүн нь тухайн байгууллагад мөн адил хүүний түвшний эрсдэл үүсгэдэг.
4. Тайлант үе бүрд тодорхойлсон уг урьдчилан таамагласан мөнгөн гүйлгээний болон дахин үнэ тогтоолтын эрсдэл нь тэдгээр урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдох үеийн зах зээлийн хүүний түвшнээр дахин хөрөнгө оруулалт хийх буюу дахин үнэ тогтоох мөнгөн орлогын гүйлгээний үндсэн дүн ба дахин санхүүжилт хийх буюу дахин үнэ тогтоох мөнгөн зарлагын гүйлгээний үндсэн дүнг илэрхийлнэ.
5. Мөнгөн гүйлгээний болон дахин үнэ тогтоолтын цэвэр эрсдэл нь хөрөнгөөс үүсэх мөнгөн орлогын гүйлгээ, дахин үнэ тогтоолтын эрсдэл ба өр төлбөрөөс үүсэх мөнгөн зарлагын гүйлгээ, дахин үнэ тогтоолтын эрсдэл хоорондох зөрүү юм. Энэ жишээний хувьд, хөрөнгөөс үүсэх эрсдэл нь өр төлбөрөөс үүсэх эрсдлээс илүү байгаа бөгөөд уг хэтрэлтийг (өөрөөр хэлбэл, цэвэр дүнг) одоогийн зах зээлийн хүүний түвшнээр дахин хөрөнгө оруулах буюу дахин үнэ тогтоох ба мөнгөн зарлагын гүйлгээний харилцан нөхөх дахин санхүүжилт болон дахин үнэ тогтоолт байхгүй учраас тухайн байгууллага нь хүүний түвшин буурах эрсдэлд өртөнө.

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

Зарим байгууллага нь өөрийн хүүгүй хугацаагүй хадгаламжийн тодорхой хэсгийг эдийн засгийн хувьд урт хугацаат өр төлбөртэй адил гэж үзэж болохыг анхаарах хэрэгтэй. Гэвч ийм хугацаагүй хадгаламж нь хүүний түвшнээс хамаарах мөнгөн гүйлгээний эрсдэл үүсгэхгүй учраас түүнийг нягтлан бодох бүртгэлийн зорилгоор уг шинжилгээнд харгалзан оруулахгүй.

Хуваарь II “Урьдчилан таамагласан цэвэр мөнгөн гүйлгээ ба дахин үнэ тогтоолтын эрсдэл” нь хүүний түвшнээс хамаарах мөнгөн гүйлгээний эрсдлийг үнэлэх болон хейжийн төлөв байдлыг тохируулах эхлэлийн цэгээс өөр бусад зүйлсээр хангахгүй юм. Иж бүрэн шинжилгээ нь эргэлтэнд буй хейжийн төлөв байдлыг агуулах бөгөөд түүнийг Хуваарь III “Хүлээгдэж буй цэвэр эрсдэл ба хейжийн төлөв байдлын шинжилгээ”-д харуулав. Энэ нь тайлант үе бүрийн урьдчилан таамагласан цэвэр мөнгөн гүйлгээний эрсдлийг (Хуваарь II-т харуулсан) одоо байгаа хейжийн төлөв байдалтай (Хуваарь I-д харуулсан) харьцуулах ба уг хейжийн харилцаанд тохируулга хийх хэрэгтэй эсэхийг харгалзан үзэх суурь үндэслэлийг бүрдүүлнэ.

<b>Хуваарь III Хүлээгдэж буй цэвэр эрсдэл ба хейжийн төлөв байдлын шинжилгээ</b>						
<i>Улирлын тайлант үе</i>	<i>X1</i>	<i>X2</i>	<i>X3</i>	<i>X4</i>	<i>X5</i>	<i>...n</i>
<i>(Нэгж)</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>
Цэвэр мөнгөн гүйлгээний болон дахин үнэ тогтоолтын эрсдэл (Хуваарь II)	3,165	3,442	2,329	2,362	2,257	x,xxx
<b>Өмнө нь эргэлтэнд байсан своп:</b>						
Тогтмол хүү хүлээн авах ба хувьсах хүү төлөх (нэрлэсэн дүн)	2,000	2,000	1,200	1,200	1,200	x,xxx
Тогтмол хүү төлөх ба хувьсах хүү хүлээн авах (нэрлэсэн дүн)	(1,000)	(1,000)	(500)	(500)	(500)	x,xxx
<b>Өмнө нь байсан свопын дараах цэвэр эрсдэл</b>	<b>2,165</b>	<b>2,442</b>	<b>1,629</b>	<b>1,662</b>	<b>1,557</b>	<b>x,xxx</b>
<b>Эргэлтэнд буй хейжийн төлөв байдлыг тохируулах ажил гүйлгээнүүд:</b>						
Тогтмол хүү хүлээн авах ба хувьсах хүү төлөх своп 1 (нэрлэсэн дүн, 10 жил)	2,000	2,000	2,000	2,000	2,000	x,xxx
Тогтмол хүү төлөх ба хувьсах хүү хүлээн авах своп 2 (нэрлэсэн дүн, 3 жил)			(1,000)	(1,000)	(1,000)	x,xxx
Свопууд ... X						x,xxx
<b>Хейж хийгээгүй цэвэр мөнгөн гүйлгээний болон дахин үнэ тогтоолтын эрсдэл</b>	<b>165</b>	<b>442</b>	<b>629</b>	<b>662</b>	<b>557</b>	<b>x,xxx</b>

Тогтоосон мөнгөн гүйлгээний эрсдэлд уг эргэлтэнд буй хүүний түвшний свопын үзүүлэх үр нөлөөг үлгэрчлэн харуулахын тулд шинжилгээний өдрөөр эргэлтэнд байгаа хүүний түвшний свопуудын нэрлэсэн дүнг тэдгээр хүүний түвшний свопууд эргэлтэнд байх тайлант үе бүрд тусган оруулна. Хүүг тайлант үе бүрд нэрлэсэн дүнгээс тооцох ба эргэлтэнд буй свопуудын хувьсах хүүний бүрэлдэхүүн хэсгийг одоогийн зах зээлийн хүүний түвшнээр улирал бүр дахин тогтоох учраас эргэлтэнд байгаа хүүний түвшний свопуудын нэрлэсэн дүнг тайлант үе бүрд тусган оруулна. Нэрлэсэн дүнгүүд нь хувьсах хүүтэй хөрөнгө ба хувьсах хүүтэй өр төлбөрийн

үндсэн дүнгийн үлдэгдэлтэй зарим талаар ижил төсөөтэй байх хүүний түвшний эрсдлийг үүсгэдэг.

Одоо байгаа хейжийн төлөв байдалд ямар хэмжээгээр тохируулга хийх шаардлагатай эсэхийг тодорхойлохын тулд тэрхүү одоо байгаа төлөв байдлыг харгалзан үзсэний дараа үлдсэн эрсдлийг дахин үнэлнэ. Байгууллагын эрсдлийн удирдлагын бодлогын дагуу тогтоосон тэвчиж болох түвшний хэмжээнд уг цэвэр эрсдлийг цаашид бууруулахын тулд хүүний түвшний свопын ажил гүйлгээг ашиглан Тайлант үе Х1-ийн эхэн дэх байдлыг Хуваарь III-ын доод хэсэгт харуулсан.

Энэхүү үлгэрчилсэн жишээнд мөнгөн гүйлгээний эрсдлийг бүрэн устгаж арилгаагүй гэдгийг анхаарах хэрэгтэй. Олон байгууллага нь эрсдлийг бүрэн устгаж арилгадаггүй боловч тэвчиж болох тодорхой хязгаарын дотор түүнийг бууруулдаг.

Урьдчилан таамагласан цэвэр мөнгөн гүйлгээний хуваарь (Хуваарь II)-т тодорхойлсон, хүүний түвшний эрсдэлд өртөх мөнгөн гүйлгээний эрсдлийг удирдан зохицуулахын тулд төрөл бүрийн үүсмэл хэрэглүүрийг ашиглаж болно. Гэвч энэхүү үлгэрчилсэн жишээний хувьд хейжийн бүх үйл ажиллагаанд хүүний түвшний свопыг ашиглана гэж төсөөлсөн. Мөн эргэлтэнд байгаа хүүний түвшний свопын зарим төлөв байдлыг дуусгавар болгох биш, харин хүүний түвшний свопыг бууруулсан тайлант үеүдэд өгөөжийн эсрэг шинж чанар бүхий шинэ свопыг тухайн багцад нэмж оруулна гэж төсөөлнө.

Дээрх Хуваарь III-д харуулсан жишээний хувьд, Тайлант үе Х1 ба Х2-ын цэвэр эрсдлийг бууруулахын тулд тогтмол хүү хүлээн авах ба хувьсах хүү төлөх Свop 1-ийг ашигласан. Энэ свop нь 10 жилийн хугацаатай учраас энд харуулаагүй ирээдүйн бусад тайлант үеүдэд тодорхойлогдох эрсдлийг бас бууруулах юм. Гэвч энэ нь Тайлант үе Х3-Х5-д хэт илүү хейж хийсэн төлөв байдлыг бий болгох үр дүтэй байна. Тайлант үе Х3-Х5-д тогтмол хүү хүлээн авах ба хувьсах хүү төлөх, эргэлтэнд буй хүүний түвшний свопуудын нэрлэсэн дүнг бууруулах, ингэснээр уг хэт хейж хийсэн төлөв байдлыг багасгахын тулд тогтмол хүү төлөх ба хувьсах хүү хүлээн авах хүүний түвшний свопоос эхэлсэн форвард буюу Свop 2-ыг ашиглана.

Мөн эрсдлийг зөвшөөрөгдөх хязгаарын дотор байлгахын тулд тухайн эргэлтэнд буй хейжийн төлөв байдалд тохируулга хийх шаардлагагүй эсвэл зөвхөн ганц тохируулга хийх шаардлагатай байдаг. Гэвч байгууллагын эрсдлийн удирдлагын бодлого нь тэвчиж болох маш бага эрсдлийг заасан тохиолдолд аливаа үлдсэн эрсдлийг цаашид бууруулахын тулд тухайн урьдчилан таамагласан тайлант үеийн туршид уг хейжийн төлөв байдалд маш олон тооны тохируулга хийх шаардлагатай болдог.

Зарим хүүний түвшний свop нь хейжийн зорилгоор байгуулсан бусад хүүний түвшний свопуудыг бүрэн нөхдөг тохиолдолд хейжийн нягтлан бодох бүртгэлийн зорилгоор уг сонгосон хейжийн харилцаанд тэдгээрийг тусган оруулах шаардлагагүй юм. Эдгээр харилцан нөхөх төлөв байдлуудыг нэгтгэн нийлүүлж, хейжийн хэрэглүүр байдлаар сонгохыг зогсоох ба хэрэв шаардлагатай бол нягтлан бодох бүртгэлийн зорилгоор хейжийн багцаас худалдаа арилжааны багц болгон дахин ангилж болно. Энэ горим нь нягтлан бодох бүртгэлийн зорилгоор нийт свопыг хейжийн харилцаанд сонгох ба хөөн шалгасан хэвээр байх шаардлагатай

хэмжээг хязгаарладаг. Энэхүү үлгэрчилсэн жишээний зорилгын хувьд, тогтмол хүү төлөх ба хувьсах хүү хүлээн авах 500 ТН-ийн хүүний түвшний своп нь Тайлант үе Х1-ийн эхэнд болон Тайлант үе Х1-Х5-ын туршид тогтмол хүү хүлээн авах ба хувьсах хүү төлөх 500 ТН-ийн хүүний түвшний свопыг бүрэн нөхнө гэж үзсэн бөгөөд хейжийн хэрэглүүр байдлаар сонгохоо больж, худалдаа арилжааны дансанд дахин ангилсан.

Эдгээр харилцан нөхөх төлөв байдлуудыг тусгасны дараа Хуваарь III-аас тооцсон, нийт хүүний түвшний свопын үлдэх төлөв байдлыг дараах байдлаар Хуваарь IV-т харуулна.

<b>Хуваарь IV Хейж гэж сонгосон хүүний түвшний своп</b>						
<i>Улирлын тайлант үе (Нэгж)</i>	<i>X1</i>	<i>X2</i>	<i>X3</i>	<i>X4</i>	<i>X5</i>	<i>...n</i>
	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>
Тогтмол хүү хүлээн авах ба хувьсах хүү төлөх (нэрлэсэн дүн)	3,500	3,500	2,700	2,700	2,700	х,xxx
Тогтмол хүү төлөх ба хувьсах хүү хүлээн авах (нэрлэсэн дүн)	(500)	(500)	(1,000)	(1,000)	(1,000)	х,xxx
<i>Эргэлтэнд буй цэвэр свопын төлөв байдал</i>	<i>3,000</i>	<i>3,000</i>	<i>1,700</i>	<i>1,700</i>	<i>1,700</i>	<i>х,xxx</i>

Энэхүү үлгэрчилсэн жишээний зорилгын хувьд Тайлант үе Х1-ийн эхэнд байгуулсан Свop 2 нь хейж гэж тайлагнаж буй бусад свопыг зөвхөн хэсэгчлэн харилцан нөхөх ба иймээс түүнийг хейжийн хэрэглүүр гэж сонгосон хэвээр байна.

*Хейжийн нягтлан бодох бүртгэлийн анхаарах зүйлс*

Хейжийн харилцааны сонголтыг үлгэрчлэн харуулах

Одоог хүртэлх хэлэлцүүлэг ба үлгэрчилсэн жишээ нь ирээдүйн тайлант үеүд дэх эрсдлийн тодорхойлолт ба хүүний түвшний свопыг ашиглан уг эрсдэлд хийх тохируулгатай холбоотой эдийн засгийн болон эрсдлийн удирдлагын анхаарах зүйлсэд юуны өмнө чиглэж байсан. Эдгээр үйл ажиллагаа нь нягтлан бодох бүртгэлийн зорилгоор хейжийн харилцааг сонгох суурь үндэслэлийг бүрдүүлнэ.

УСНББОУС 29 дэх жишээнүүд нь нэг хейжийн зүйл ба нэг хейжийн хэрэглүүр бүхий хейжийн харилцаанд үндсэндээ чиглэдэг боловч эрсдлийг төвлөрсөн байдлаар удирдан зохицуулах үед мөнгөн гүйлгээний хейжид зориулсан багцын хейжийн харилцааны талаархи цөөн хэлэлцүүлэг болон заавар удирдамжийг үүнд тусгасан. Энэ жишээний хувьд, олон ажил гүйлгээ болон төлөв байдлуудаас үүсэх янз бүрийн эрсдэл бүхий багц дахь эрсдлийн бүрэлдэхүүн хэсгийг агуулсан хейжийн харилцаанд ерөнхий зарчмуудыг мөрдөнө.

Хейжийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэхийн тулд сонголтыг хийх зайлшгүй шаардлагатай боловч уг сонголтыг тодорхойлох арга зам нь тухайн хейжийн харилцааг нягтлан бодох бүртгэлийн зорилгоор үр дүнтэй гэж дүгнэн үзэх хэмжээнд, түүнчлэн нягтлан бодох бүртгэлийн зорилгоор хейжийн харилцааг хөөн шалгахын тулд уг байгууллагын эрсдлийн удирдлагын одоогийн системд засвар өөрчлөлт оруулах шаардлагатай хэмжээнд бас нөлөө үзүүлдэг. Иймээс байгууллага нь уг эрсдлийн удирдлагын системээр нэгэнт бий болгосон



мэдээллийн давуу талыг ашигласнаар тэрхүү системд шаардлагагүй өөрчлөлт оруулахаас зайлсхийх, хэрэгцээгүй бүртгэл хөтлөх ба хөөн шалгалт хийхээс зайлсхийх тийм арга маягаар тухайн хейжийн харилцааг сонгохыг хүсэж болох юм. Хейжийн харилцааг сонгох үедээ, байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн зорилгоор бусад хувилбар сонголтуудын дагуу хүлээн зөвшөөрөхөөр хүлээгдэж буй үр дүнгүй байдлын хэмжээг мөн харгалзан үзэж болно.

Хейжийн харилцааны сонголт нь янз бүрийн асуудлуудыг тусгайлан тодорхойлох шаардлагатай. Мөнгөн орлогын гүйлгээтэй холбоотой хүүний түвшний эрсдлийн хейж талаас эдгээр асуудлуудыг энд үлгэрчлэн харуулж, авч хэлэлцсэн боловч уг заавар удирдамжийг мөнгөн зарлагын гүйлгээтэй холбоотой эрсдлийн хейжийн хувьд бас мөрдөнө. Нийт эрсдлийн зөвхөн мөнгөн орлогын гүйлгээтэй холбоотой хэсэгт уг хүүний түвшний свопоор хейж хийж байна гэдэг нь ойлгомжтой тодорхой юм. Хавсралт II-д тодорхойлсон дахин хөрөнгө оруулалтын нийт эрсдлээс хүүний түвшний свопоор хейж хийгдэж буй хэсгийн сонголтыг Хуваарь V-Хейжийн ерөнхий харилцаанд үлгэрчлэн харуулсан.

<b>Хуваарь V Хейжийн ерөнхий харилцаа</b>						
<i>Улирлын тайлант үе</i>	<i>X1</i>	<i>X2</i>	<i>X3</i>	<i>X4</i>	<i>X5</i>	<i>...n</i>
<i>(Нэгж)</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>	<i>ТН</i>
Мөнгөн орлогын гүйлгээний дахин үнэ тогтоолтын эрсдэл (Хуваарь II)	14,100	12,689	11,687	9,700	9,409	х,xxx
Тогтмол хүү хүлээн авах ба хувьсах хүү төлөх своп (Хуваарь IV)	3,500	3,500	2,700	2,700	2,700	х,xxx
<i>Хейж хийсэн эрсдлийн хувийн жин</i>	<i>24.8%</i>	<i>27.69%</i>	<i>23.1%</i>	<i>27.8%</i>	<i>28.7%</i>	<i>х,xxx</i>

Эргэлтэнд буй тогтмол хүү хүлээн авах ба хувьсах хүү төлөх свопуудын нэрлэсэн дүнг нийт эрсдэлд хуваасан харьцаа байдлаар уг хейж хийсэн эрсдлийн хувийн жинг тооцоолдог. Хуваарь V-ын хувьд, тогтмол хүү хүлээн авах ба хувьсах хүү төлөх свопуудын нэрлэсэн дүнгээс илүү их харилцан нөхөлт хийх, урьдчилан таамагласан хангалттай хэмжээний дахин хөрөнгө оруулалт тайлант үе бүрд байгаа бөгөөд тухайн урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь өндөр магадлалтай байх гэсэн хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангана гэдгийг анхаарах хэрэгтэй.

Гэвч хүүний түвшний своп нь хейж хийгдэж буй гэж сонгосон мөнгөн гүйлгээний хүүний эрсдэлд хэр тусгайлан хамаарах ба тэрхүү эрсдлийг бууруулахад уг хүүний түвшний своп хэр үр дүнтэй эсэх нь тийм ч илт тодорхой байдаггүй. Илүү тусгайлсан хейжийн сонголтыг доорх Хуваарь VI-Хейжийн тусгай харилцаанд харуулав. Энэ хуваарь нь хүүний түвшний ирээдүйн өөрчлөлттэй холбоотой мөнгөн гүйлгээний хувьсан өөрчлөлтийг цэвэрлэх ба хейжийн эхэнд байсан хүүний түвшний хугацааны бүтцэд угаасаан тусгасан тогтмол хүүтэй тэнцүү хүүний түвшнийг тогтоохын тулд хейжийн зорилтуудад голчлон анхаарах замаар хейжийг илүү нарийвчилсан, хүүрнэсэн хэлбэрийн сонголтыг илэрхийлэх ач холбогдолтой арга зам юм.

Эрсдэлд өртөх нийт дүнг тухайн тайлант үеийн форвард хүүний түвшнээр үржүүлснээр уг мөнгөн орлогын гүйлгээний дахин хөрөнгө оруулалтаас болон тухайн хөрөнгийн үнийн дахин тогтоолтоос үүсэх хүлээгдэж буй хүүг тооцоолно. Жишээлбэл; хүүний түвшний одоогийн хугацааны бүтцэд үндэслэн улирал тутмын

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

тайлант үеүдэд хүлээгдэж буй хүүг тооцоолохын тулд Тайлант үе Х2-Х5-ын хувьд харгалзан 5.50%, 6.00%, 6.50%, 7.25% гэсэн форвард хүүний түвшнээр Тайлант үе Х2-ын нийт 14,100 ТН-ийн эрсдлийг үржүүлнэ. Холбогдох гурван сарын тайлант үед хүлээгдэж буй хүүний түвшинг уг хейж хийсэн эрсдлийн хувийн жингээр үржүүлснээр тухайн хейж хийсэн хүлээгдэж буй хүүг тооцоолно.

<b>Хуваарь VI Хейжийн тусгай харилцаа</b>							
<i>Хүүний түвшний бүтэц</i>							
<i>Улирлын тайлант үе</i>	<i>X1</i>	<i>X2</i>	<i>X3</i>	<i>X4</i>	<i>X5</i>	<i>...n</i>	
Спот хүүний түвшин	5.00%	5.25%	5.50%	5.75%	6.05%	х.хх%	
Форвард хүүний түвшин <sup>(a)</sup>	5.00%	5.50%	6.00%	6.50%	7.25%	х.хх%	
<i>Мөнгөн гүйлгээний эрсдэл ба хүлээгдэж буй хүүний дүн</i>							
Дахин үнэ тогтоох тайлант үе	Ажил гүйлгээг урьдчилан таамаглах хугацаа	Эрсдэлд өртөх нийт дүн	ТН	ТН	ТН	ТН	
						Хүлээгдэж буй хүү ТН	
2	3 сар	14,100	→	<b>194</b>	212	229	
3	6 сар	12,689			<b>190</b>	206	
4	9 сар	11,687				<b>190</b>	
5	12 сар	9,700				<b>176</b>	
6	15 сар	9,409				<b>xxx</b>	
Өмнөх тайлант үед хейж хийсэн хувийн жин (Хуваарь V)				24.8%	27.6%	23.1%	27.8%
Хейж хийсэн хүлээгдэж буй хүү				48	52	44	69
						хх.х%	
(a) Форвард хүүний түвшинг уг спот хүүний түвшнүүдээс тооцоолсон ба энэ толилуулгын зорилгоор бүхэлчилсэн. Форвард хүүний түвшнүүдэд үндэслэсэн тооцооллыг уг бодитойгоор тооцоолсон форвард хүүний түвшинд тулгуурлан хийсэн бөгөөд дараа нь, энэ толилуулгын зорилгоор бүхэлчилсэн.							

Эрсдэлд өртөх нийт дүнгээр тогтмол хүүтэй буюу хувьсах хүүтэй урт хугацаат өрийн хэрэглүүрт дахин хөрөнгө оруулалт хийх, эсвэл дараагийн тайлант үе бүрд цаашид дахин шилжүүлэх богино хугацаат өрийн хэрэглүүрт дахин хөрөнгө оруулалт хийх эсэх нь хамааралгүй юм. Форвард хүүний түвшний өөрчлөлтийн эрсдэл нь ижил байна. Жишээлбэл; уг 14,100 ТН-ээр Тайлант үе 2-ын эхэнд тогтмол хүүтэй, зургаан сарын хугацаатай дахин хөрөнгө оруулалт хийсэн бол энэ нь 5.75 хувийн хүүтэй дахин хөрөнгө оруулалт болно. Энэхүү хүлээгдэж буй хүү нь Тайлант үе Х2-ын 5.50 хувийн болон Тайлант үе Х3-ын 6.00 хувийн форвард хүүний түвшинд үндэслэх бөгөөд эдгээрийн холимог 5.75 хувь  $(1.055 \times 1.060)^{05}$  нь дараагийн зургаан сарын турш дахь Тайлант үе Х2-ын спот хүүний түвшин юм.

Гэвч уг урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдсоны дараах зөвхөн эхний гурван сарын хувьд мөнгөн орлогын гүйлгээний дахин хөрөнгө оруулалт буюу нийт дүнгийн дахин үнэ тогтоолтоос үүсэхээр хүлээгдэж буй хүүг хейж хийгдэж буй гэж сонгоно. Хүлээгдэж буй, хейж хийгдэж байгаа хүүг тод хар өнгөөр илэрхийлсэн. Дараагийн тайлант үеүдийн эрсдэлд хейж хийгээгүй. Энэ жишээнд, хейж хийгдэж буй хүүний түвшний эрсдлийн хэсэг нь Тайлант үе Х2-ын хувьд 5.50 хувийн форвард хүүний түвшин байна. Тасралтгүй байдлаар хейжийн үр дүнтэй байдлыг үнэлэх ба хейжийн бодит үр дүнгүй байдлыг тооцоолохын тулд байгууллага нь Хуваарь VI-д харуулсан, хейж хийсэн хүүний мөнгөн орлогын

гүйлгээний мэдээллийг ашиглах ба хүлээгдэж буй хүүний мөнгөн орлогын гүйлгээний өөрчлөн баяжуулсан тооцоололтой үүнийг дараа нь харьцуулж болно (жишээлбэл; Хуваарь II-тай адил хүснэгтэд харуулсан байдлаар). Хүлээгдэж буй хүүний мөнгөн орлогын гүйлгээ нь хейж хийсэн хүүний мөнгөн орлогын гүйлгээнээс илүү байх тохиолдолд бодит хейжийн үр дүнтэй байдлыг тооцоолохын тулд байгууллага нь хейж хийсэн мөнгөн орлогын гүйлгээний бодит үнэ цэнийн хуримтлагдсан өөрчлөлтийг уг хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хуримтлагдсан өөрчлөлттэй харьцуулж болно. Хүлээгдэж буй хүүний мөнгөн орлогын гүйлгээ нь хангалтгүй бол үр дүнгүй байдал үүснэ. Хүлээгдэж буй хүүний мөнгөн гүйлгээний бодит үнэ цэнийн хуримтлагдсан өөрчлөлт нь тухайн хейж хийсэн мөнгөн гүйлгээнээс бага байх тохиолдолд тэрхүү хуримтлагдсан өөрчлөлтийг уг хейжийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хуримтлагдсан өөрчлөлттэй харьцуулснаар үр дүнгүй байдлыг хэмжинэ.

*Хейжийн харилцааны сонголтыг тайлбарлан тодорхойлох*

Өмнө дурдсанчлан, хейжийн сонголтын тайлбар тодорхойлолтыг нарийн төвөгтэй болгодог боловч нягтлан бодох бүртгэлийн зорилгоор хүлээн зөвшөөрөх үр дүнгүй байдлыг хязгаарлах ба шаардлагагүй системийн өөрчлөлт, бүртгэл хөтлөлтөөс зайлсхийхэд зайлшгүй шаардагдах тухайн хейжийн харилцаанд тусгайлан заавал зохих янз бүрийн асуудлууд байдаг. Дараах жишээ нь хейжийн сонголтыг илүү бүрэн тайлбарлан тодорхойлох бөгөөд өмнөх үлгэрчилсэн жишээнээс илт тодорхой харагдахгүй уг хейжийн нэмэлт төлөв байдлуудыг тодорхойлно.

<b>Хейжийн сонголтын жишээ</b>
<p><i>Хейжийн зорилго</i></p> <p>Хейжийн зорилго нь хейжийн хугацаанд, өөрөөр хэлбэл хүүний түвшний свопын хугацаанд хүүний түвшин хэлбэлзэх эрсдлийг бууруулах, ингэснээр энэ хугацааны туршид хүүний түвшний свопын тогтмол хүүний түвшинтэй тэнцүү байх тогтмол хүүний түвшинг тогтоох явдал юм.</p> <p><i>Хейжийн төрөл</i></p> <p>Мөнгөн гүйлгээний хейж</p> <p><i>Хейжийн хэрэглүүр</i></p> <p>Тогтмол хүү хүлээн авах ба хувьсах хүү төлөх свопыг хейжийн хэрэглүүр гэж сонгосон. Ийм своп нь хүүний түвшний эрсдлээс хамаарах мөнгөн гүйлгээний эрсдэл өртөлтөнд хейж хийнэ.</p> <p>Свопын дахин үнэ тогтоолт бүр нь доорх зүйлсээс үүсэх хүүний мөнгөн орлогын гүйлгээний гурван сарын хугацаанд хамаарах хэсэгт хейж хийнэ:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хуваарь V-д харуулсан, үндсэн дүнгүүдийн урьдчилан таамагласан дахин хөрөнгө оруулалт буюу дахин үнэ тогтоолт.</li> <li>• Дахин үнэ тогтоолтын өдрийн уг свопын хувьд түүний хугацааны туршид хийгдсэн бөгөөд өөр өөр зээлдэгчид буюу зээлдүүлэгчдийг хамрах харилцан хамааралгүй хөрөнгө оруулалт буюу дахин үнэ тогтоолт.</li> </ul>

*Хейжийн зүйл – Ерөнхий*

Хейжийн зүйл нь Хуваарь V-д тодорхойлсон мөнгөн гүйлгээний дахин хөрөнгө оруулалт буюу дахин үнэ тогтоолтоос үүсэх бөгөөд ийм Хуваарьт харуулсан тайлант үеүдийн дотор гарч тохиолдохоор хүлээгдэж буй нийт хүүний мөнгөн орлогын гүйлгээний хэсэг юм. Хүүний мөнгөн орлогын гүйлгээний хейж хийгдэж буй хэсэг нь дараах гурван бүрэлдэхүүн хэсэгтэй байна:

- Хүүний мөнгөн орлогын гүйлгээ үүсэхэд хүргэж буй үндсэн дүнгийн бүрэлдэхүүн хэсэг ба түүний гарч тохиолдох тайлант үе;
- Хүүний бүрэлдэхүүн хэсэг; ба
- Хугацааны бүрэлдэхүүн хэсэг буюу хейжид хамаарах тайлант үе.

*Хейжийн зүйл – Үндсэн дүнгийн бүрэлдэхүүн хэсэг*

Хейж хийгдэж буй хүүний мөнгөн орлогын гүйлгээний хэсэг нь тайлант үе бүрт хөрөнгө оруулсан буюу дахин үнэ тогтоосон үндсэн дүнгийн эхний хэсгийн үр дүн болох дүнгүүд байна:

- Энэ нь хейжийн хэрэглүүр гэж сонгосон дахин хөрөнгө оруулалт хийсэн буюу дахин үнэ тогтоосон тайлант үед эргэлтэнд буй тогтмол хүү хүлээн авах ба хувьсах хүү төлөх хүүний түвшний свопуудын нэрлэсэн дүнгүүдийн нийлбэртэй тэнцүү байна; ба
- Энэ нь хүүний түвшний свопуудын дахин үнэ тогтоолтын өдрөөр буюу түүнээс хойш хөрөнгө оруулсан эсвэл дахин үнэ тогтоосон мөнгөн гүйлгээний эхний үндсэн дүнгүүдийн эрсдэлд хамаарна.

*Хейжийн зүйл – Хүүний түвшний бүрэлдэхүүн хэсэг*

Хейж хийгдэж буй хүүний түвшний өөрчлөлтийн хэсэг нь дараах хоёр зүйлсийн аль алины өөрчлөлт байна:

- Дахин хөрөнгө оруулсан буюу дахин үнэ тогтоосон үндсэн дүнгээс төлж буй зээлийн хүүний зээлийн бүрэлдэхүүн хэсэг, энэ нь уг хүүний түвшний свопод угаасаа байдаг зээлийн эрсдэлтэй тэнцүү байна. Энэ нь хүүний түвшний свопын ЛАЙБОР гэх мэт хүүний индекстэй тэнцүү уг хөрөнгө оруулалтын хүүний түвшний хэсэг юм; ба
- Хүүний түвшний өгөөжийн муруйн хэсэг, энэ нь хейжийн хэрэглүүр гэж сонгосон хүүний түвшний свопын хувьд дахин үнэ тогтоох хугацаатай тэнцүү байна.

*Хейжийн зүйл – Хейжийн хугацаа*

Хейж хийгдэж буй мөнгөн гүйлгээний хэсэгт хүүний түвшний өөрчлөлтийн улмаас эрсдэл үүсэх хугацаа нь:

- Хейжийн сонголтын өдрөөс уг хүүний түвшний свопын дахин үнэ тогтоолтын өдөр хүртэлх хугацаа; дахин үнэ тогтоолтын өдөр нь тухайн урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдох улирлын тайлант үеийн дотор байх боловч тэрхүү урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдохоос өмнө байж болохгүй; ба
- Урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдсоны дараах тайлант үед түүний үзүүлэх үр нөлөө нь уг хүүний түвшний свопын дахин үнэ тогтоолтын хугацааны мужтай тэнцүү байна.

Своп нь нэг хөрөнгө оруулалтын хувьд түүний нийт хугацааны мөнгөн гүйлгээний эрсдэлд хейж хийхгүй гэдгийг хүлээн зөвшөөрөх нь чухал юм. Свопын нийт хугацааны турш дахь түүний дахин үнэ тогтоолтын тайлант үе бүрд хийх үндсэн дүнгийн өөр өөр хөрөнгө оруулалтууд болон дахин үнэ тогтоолтоос үүсэх мөнгөн гүйлгээний эрсдлийн хейж гэж свопуудыг сонгодог. Своп нь дахин хөрөнгө оруулалтын дараах эхний тайлант үед гарч тохиолдох зөвхөн хүүний хуримтлуулалтанд хейж хийдэг. Своп нь түүний дахин үнэ тогтоолтын өдөр хүртэл гарч тохиолдсон хүүний түвшний өөрчлөлтүүдээс үүсэх мөнгөн гүйлгээний үр нөлөөнд хейж хийдэг. Свопын дахин үнэ тогтоолтын өдрөөс мөнгөн орлогын гүйлгээний хейж хийсэн дахин хөрөнгө оруулалтын буюу хувьсах хүүтэй хөрөнгийн дахин үнэ тогтоолтын өдөр хүртэлх хугацаан дахь хүүний түвшний өөрчлөлтүүдийн эрсдэлд хейж хийдэггүй. Свопын үнийг дахин тогтоодог тохиолдолд уг свопын хүүний түвшин нь дараагийн дахин үнэ тогтоох өдөр болон свопын цэвэр барагдуулалтын хуримтлагдсан дүнг тодорхойлох өдөр хүртэлх хугацаанд тогтмол байна. Хүүний мөнгөн орлогын гүйлгээний дүнд нөлөөлөх өдрөөс хойш хүүний түвшинд гарсан аливаа өөрчлөлтөд нягтлан бодох бүртгэлийн зорилгоор цаашид хейж хийхгүй.

#### *Хейжийн сонголтын зорилго*

#### Системийн анхаарах зүйлс

Мөнгөн орлогын гүйлгээний урьдчилан таамагласан дахин хөрөнгө оруулалтаас үүсэх мөнгөн гүйлгээний эрсдлийн, түүнчлэн холбогдох хөрөнгийн ашиглалтын хугацааны зөвхөн тодорхой хэсгийн хувьд хувьсах хүүтэй хөрөнгийн дахин үнэ тогтоолтоос үүсэх мөнгөн гүйлгээний эрсдлийн хейж гэж хүүний түвшний свопыг түүний дахин үнэ тогтоолт бүрээр сонгосноор хөөн шалгалтын болон бүртгэл хөтлөлтийн олон шаардлагуудаас чөлөөлдөг. Харин урьдчилан таамагласан үндсэн дүнгийн хөрөнгө оруулалтаас болон тэдгээр хөрөнгүүдийн нийт хугацаан дахь хувьсах хүүтэй хөрөнгийн дахин үнэ тогтоолтоос үүсэх мөнгөн гүйлгээний эрсдлийн хейж гэж свопуудыг сонгодог бол илүү олон хөөн шалгалт ба бүртгэл хөтлөлт шаардлагатай болох юм.

Хейж хийгдэж буй мөнгөн гүйлгээний эрсдлийн хэсэг нь урьдчилан таамагласан ажил гүйлгээний яг дараах тайлант үед ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх ба уг свопын үечилсэн цэвэр мөнгөн барагдуулалттай уялдах тэрхүү хэсэг учраас ийм төрлийн хейжийн сонголт нь тухайн урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдсоны дараа, цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн олз, гарзыг хөөн шалгах шаардлагагүй болгодог (УСНББОУС 29-ийн 108-р параграф ба УСНББОУС 29-ийн 109-р параграф). Хэрэв хейж нь тухайн олж эзэмшиж буй хөрөнгийн нийт хугацааг хамрах бол уг тодорхой хүүний түвшний свопыг тэрхүү олж эзэмшиж байгаа хөрөнгөтэй уялдуулах шаардлагатай байдаг. Хэрэв урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь тогтмол хүүтэй хэрэглүүрийн худалдан авалт бол хүүний орлогыг хүлээн зөвшөөрөх үед тухайн хөрөнгийн хүүний орлогыг тохируулахын тулд тэрхүү ажил гүйлгээнд хейж хийж буй свопын бодит үнэ цэнийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Дараа нь, уг свопыг дуусгавар болгох буюу өөр хейжийн харилцаанд дахин сонгох шаардлагатай болдог. Хэрэв урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь хувьсах хүүтэй хөрөнгийн худалдан авалт бол своп нь уг хейжийн харилцаанд хэвээр үлдэх боловч цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн свопын бодит үнэ

цэнийн аливаа дүнг тухайн хөрөнгийг дараа нь борлуулах тэр үед ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөхийн тулд свопыг тухайн олж эзэмшсэн хөрөнгөнд буцаан хөөн шалгах шаардлагатай байдаг.

Энэ нь мөн цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн свопын бодит үнэ цэнийн аливаа хэсэгтэй уг хувьсах хүүтэй хөрөнгийг уялдуулах шаардлагагүй болгодог. Үүний үр дүнд, урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдсон эсвэл хувьсах хүүтэй хөрөнгийг борлуулсан үед ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх шаардлагатай боловч цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн тийм свопын бодит үнэ цэнийн хэсэггүй болоход хүргэх юм.

Мөн энэ төрлийн хейжийн сонголт нь мөнгөн гүйлгээ гарч тохиолдсон үед түүгээр хэрхэн дахин хөрөнгө оруулалт хийх эсэхийг шийдвэрлэхдээ уян хатан хандах боломжийг бүрдүүлдэг. Хейж хийсэн эрсдэл нь хейжийн хэрэглүүр гэж сонгосон хүүний түвшний свопын дахин үнэ тогтоолтын хугацаатай уялдсан зөвхөн нэг тайлант үед хамаарах учраас тэрхүү мөнгөн гүйлгээгээр тогтмол хүүтэй эсвэл хувьсах хүүтэй хөрөнгөнд дахин хөрөнгө оруулалт хийх эсэхийг уг хейжийн сонголтын өдөр тодорхойлох, эсвэл тухайн олж эзэмших хөрөнгийн ашиглалтын нийт хугацааг хейжийн сонголтын өдөр тусгайлан заах шаардлагагүй юм.

#### Үр дүнтэй байдлын анхаарах зүйлс

Мөнгөн гүйлгээний эрсдлийн тодорхой хэсгийг түүнд хейж хийсэн гэж сонгосноор үр дүнгүй байдлыг ихээхэн бууруулдаг.

- АА зэрэглэлийн өгөөжийн муруй гэх мэт тухайн свопын угийн хүүний түвшинтэй уялдсан хүүний түвшний өөрчлөлтөнд хамааруулж болох эрсдэл байдлаар тэрхүү хейж хийж буй мөнгөн гүйлгээний эрсдлийг сонгосноор хүүний түвшний своп ба хейж хийсэн, урьдчилан таамагласан мөнгөн гүйлгээ хоорондох зээлийн зөрүүтэй байдлаас үүссэн үр дүнгүй байдлыг арилгадаг. Ийм төрлийн хейжийн сонголт нь зээлийн тархалтын өөрчлөлтийн үр дүн болох тийм өөрчлөлтийг хейжийн үр дүнгүй байдал гэж үзэхээс сэргийлдэг.
- Хүүний түвшний свопын хувьсах хүүтэй хэсгийн дахин үнэ тогтоох хугацаатай уялдсан өгөөжийн муруйн тэрхүү хэсгийн өөрчлөлттэй холбоотой эрсдэл байдлаар хейж хийгдэж буй гэж хүүний түвшний эрсдлийг сонгосноор тухайн хүүний түвшний своп ба хейж хийсэн урьдчилан таамагласан мөнгөн гүйлгээ хоорондох хугацааны зөрүүтэй байдлаас хамаарсан үр дүнгүй байдлыг арилгадаг.
- Хүүний түвшний свопын дахин үнэ тогтоох өдөр ба урьдчилан таамагласан ажил гүйлгээний өдөр хооронд гарч тохиолдсон хүүний түвшний өөрчлөлтийн улмаас үүсэх үр дүнгүй байдлыг тухайн хугацаанд хейж хийхгүй байснаар хялбархан арилгаж болно. Свопын дахин үнэ тогтоолтын өдрөөс тэрхүү свопын дахин үнэ тогтоолтын яг дараах тайлант үед уг урьдчилан таамагласан ажил гүйлгээ гарч тохиолдох хүртэлх хугацаанд хейж хийхгүй орхидог. Иймээс хугацааны зөрүү нь үр дүнгүй байдал үүсгэхгүй.

*Нягтлан бодох бүртгэлийн анхаарах зүйлс*

Энд дурдсан арга зүйг ашиглан хейжийн нягтлан бодох бүртгэлийн шалгуурыг хангах чадвар боломж нь УСНББОУС 29-ийн заалтууд болон түүний шаардлагуудын тайлбарт үндэслэдэг. Тэдгээр зарим заалт, тайлбарыг Асуулт Е.6.2, “Хүүний түвшний эрсдлийг цэвэр дүнгээр удирдан зохицуулдаг үеийн хейжийн нягтлан бодох бүртгэлийн анхаарах зүйлс”-ийн хариултад дурдсан. Зарим нэмэлт болон дэмжих заалт, тайлбарыг доор тодорхойлов.

Эрсдлийн зарим хэсгийн хейж

Мөнгөн гүйлгээгээр хийх дахин хөрөнгө оруулалтаас эсвэл хувьсах хүүтэй хэрэглүүрийн дахин үнэ тогтоолтоос үүсэх мөнгөн гүйлгээний эрсдлийн зөвхөн зарим хэсгийг тодорхойлох ба хейж хийх чадвар боломжийг Асуулт Е.6.2(м) ба Е.2.17, “Хэсэгчилсэн хугацааны хейж”-ийн хариултад тайлбарласанчлан, УСНББОУС 29-ийн 90-р параграфтаас үзэж болно.

Олон эрсдэлд нэг хэрэглүүрээр хейж хийх

Мөнгөн орлогын гүйлгээний янз бүрийн дахин хөрөнгө оруулалтаас эсвэл хувьсах хүүтэй хөрөнгийн үнийг тухайн свопын хугацаанд дахин тогтоосноор хүүний түвшнүүдээс хамаарах мөнгөн гүйлгээний эрсдлийн хейж гэж хүүний түвшний нэг свопыг сонгох чадвар боломжийг Асуулт Е.1.12, “Нэгээс олон төрлийн эрсдлийн хейж”-ийн хариултад тайлбарласанчлан, УСНББОУС 29-ийн 85-р параграфтаас үзэж болно.

Багц дахь ижил төсөөтэй эрсдлүүдэд хейж хийх

Хэрэглүүрийн хүлээгдэж буй нийт хугацааг тухайн хейжийн сонголтын өдөр тусгайлан заахгүй ба тогтмол хүү эсвэл хувьсах хүү төлөх эсэхийг мөн заагаагүй тийм хүүний төлбөрүүд үүсэхэд хүргэх уг хөрөнгө оруулалтын хугацааны тэрхүү хэсгийн хувьд хүүний түвшнээс хамаарсан мөнгөн гүйлгээний эрсдлийн хэсэг байдлаар уг урьдчилан таамагласан ажил гүйлгээнд хейж хийсэн гэдгийг илэрхийлэх чадвар боломжийг Асуулт Е.6.2-ын Асуудал (а)-гийн хариултаас үзэж болно. Энэ нь хейж хийж буй гэж сонгосон тухайн эрсдлийг хуваалцдаг бол уг багц дахь зүйлс нь тэрхүү ерөнхий эрсдэл өртөлттэй заавал ижил эрсдэлтэй байх албагүй гэдгийг дээрх Асуулт Е.6.2-ын Асуудал (а)-гийн хариултад заасан байдаг.

Хейжийг дуусгавар болгох

Урьдчилан таамагласан ажил гүйлгээнд (свопын дахин үнэ тогтоолтын өдрийн дараа гарч тохиолдох хөрөнгө оруулалтын буюу дахин үнэ тогтоолтын мөнгөн гүйлгээний эрсдэлд) хейж хийж буй гэсэн сонголтыг болих чадвар боломжийг хейжийн дуусгавар болголтын талаархи УСНББОУС 29-ийн 112-р параграфт заасан байдаг. Урьдчилан таамагласан ажил гүйлгээний зарим хэсэгт цаашид хейж хийхгүй боловч хүүний түвшний свопын хейжийн сонголтыг зогсоохгүй бөгөөд тэрхүү цуврал дахь хараахан гарч тохиолдоогүй байгаа үлдсэн ажил гүйлгээнүүдийн хувьд хейжийн хэрэглүүр хэвээр байна. Жишээлбэл; нэг жилийн үлдсэн ашиглалтын хугацаатай хүүний түвшний свопыг улирал тутмын гурван удаагийн мөнгөн гүйлгээний дахин хөрөнгө оруулалтын цувралын хувьд хейж гэж

сонгосон гэж үзье. Мөнгөн гүйлгээний урьдчилан таамагласан дараагийн дахин хөрөнгө оруулалтыг гурван сарын дараа хийнэ. Хүүний түвшний свопын үнийг гурван сарын дараа тухайн үеийн хувьсах хүүний түвшнээр дахин тогтоодог тохиолдолд уг хүүний түвшний свопын тогтмол ба хувьсах хүүний түвшин нь тодорхой мэдэгдэх бөгөөд дараагийн гурван сарын хугацаанд цаашид хейжийн хамгаалалт хийхгүй. Хэрэв дараагийн урьдчилан таамагласан ажил гүйлгээ нь гурван сар арав хоног өнгөрөх хүртэл хийгдэхгүй бол уг хүүний түвшний свопын дахин үнэ тогтоолтын дараа үлдсэн арав хоногийн хугацаанд хейж хийхгүй.

#### **Е.6.4 Хейжийн нягтлан бодох бүртгэл: Форвард арилжааны гэрээний урамшуулал буюу хөнгөлөлт**

**Форвард арилжааны гэрээг жишээлбэл, гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хейжид хейжийн хэрэглүүр гэж сонгодог. Уг форвард арилжааны гэрээний хөнгөлөлт буюу урамшууллыг тухайн гэрээний хугацаанд ашиг, алдагдалд тусган хорогдуулахыг зөвшөөрдөг үү?**

Үгүй. Форвард арилжааны гэрээний хөнгөлөлт буюу урамшууллыг УСНББОУС 29-ийн дагуу ашиг, алдагдалд хорогдуулахгүй. Үүсмэл хэрэглүүрийг санхүүгийн байдлын тайланд ямагт бодит үнэ цэнээр хэмждэг. Форвард арилжааны гэрээг мөнгөн гүйлгээний хейжид эсвэл гадаад үйл ажиллагаанд оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хейжид хейжийн хэрэглүүр гэж сонгосон ба үр дүнтэй, ингэснээр форвард арилжааны гэрээний бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарзын үр дүнтэй хэсгийг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрдөг байхаас бусад тохиолдолд ийм олз, гарзыг ямагт ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд уг хейж хийсэн ирээдүйн мөнгөн гүйлгээ гарч тохиолдсон эсвэл цэвэр хөрөнгө оруулалтыг данснаас хассан аль тохиромжтой үед цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрч байсан тэрхүү дүнг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Форвард гэрээний бодит үнэ цэнийн хүүний элементийг (цаг хугацааны үнэ цэнийг) тухайн сонгосон хейжийн харилцаанаас УСНББОУС 29-ийн 84(б) параграфт заасны дагуу хасаж болох юм. Ийм тохиолдолд форвард арилжааны гэрээний бодит үнэ цэнийн хүүний элементийн хэсгийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

#### **Е.6.5 УСНББОУС 29 ба УСНББОУС 4 – Өртгөөр хэмжсэн хөрөнгийн бодит үнэ цэнийн хейж**

**Гадаад валютаар илэрхийлсэн зээлээс үүсэх ханшийн эрсдлээс хамгаалахын тулд түүхэн өртгөөр бүртгэсэн усан онгоцны ирээдүйн борлуулалтанд хейж хийсэн бол хэдийгээр тухайн хөрөнгийн хэмжилтийн суурь нь түүхэн өртөг боловч ханшийн өөрчлөлтийн хувьд уг усан онгоцыг дахин хэмжиж, илэрхийлэхийг УСНББОУС 29-өөр шаардах уу?**

Үгүй. Бодит үнэ цэнийн хейжийн хувьд, хейжийн зүйлийг дахин хэмждэг. Гэвч усан онгоц нь тусдаа хэмжиж болох гадаад валютын ямар нэг эрсдлийг агуулдаггүй учраас гадаад валютын зээлийг усан онгоцны бодит үнэ цэнийн хейж гэж ангилж болохгүй. УСНББОУС 29-ийн 98-р параграфт заасан хейжийн нягтлан бодох бүртгэлийн нөхцлүүд хангагдаж байвал уг гадаад валютаар илэрхийлсэн зээлийг тэрхүү гадаад валютаар урьдчилан таамагласан борлуулалтын хувьд мөнгөн



гүйлгээний хейж гэж ангилж болно. Мөнгөн гүйлгээний хейжийн хувьд, хейжийн зүйлийг дахин хэмждэггүй.

### **Хэсэг Ж: Бусад**

#### *Ж.1 Бодит үнэ цэнийн өөрчлөлтийн тодруулга*

**УСНББОУС 29 нь санхүүгийн хөрөнгийг борлуулах боломжтой (ББ) гэж ангилахыг, мөн ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг бодит үнэ цэнээр дахин хэмжихийг шаарддаг. Санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг мөнгөн гүйлгээний хейжийн хэрэглүүр гэж сонгосноос бусад тохиолдолд ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх ба ББ хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө. Тухайн тайлант үеийн турш дахь бодит үнэ цэнийн өөрчлөлтийн дүнгийн талаар ямар тодруулга хийх шаардлагатай вэ?**

Орлого, зардал ба олз, гарзын зүйлсийг тодруулахыг УСНББОУС 30-ын 23-р параграфтаар шаарддаг. Энэхүү тодруулгын шаардлага нь бодит үнэ цэнээр дахин хэмжсэнээр үүсэх орлого, зардал, олз, гарзын зүйлсэд хамаардаг. Иймээс байгууллага нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн өөрчлөлт ба цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн өөрчлөлтийг өөр хооронд нь ялган зааглаж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийн талаархи тодруулгыг хийдэг. Дараах зүйлсэд хамаарах байдлаар өөрчлөлтийн дэлгэрэнгүй задаргааг хийдэг:

- (a) ББ Хөрөнгө, энд тухайн тайлант үеийн туршид цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрсөн олз, гарзын дүн ба тухайн тайлант үеийн туршид ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн дүнг тусад нь харуулах;
- (б) Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр, энд тухайн санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийг (i) анх хүлээн зөвшөөрөхдөө ингэж сонгох, (ii) худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж УСНББОУС 29-ийн дагуу ангилах үеийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тусад нь харуулах;
- (в) Хейжийн хэрэглүүр.

Дотоод тайлагналын зорилгоор зүйлсийг ангилах арга замын дагуу уг бодит үнэ цэнийн өөрчлөлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тодруулахыг УСНББОУС 30-аар шаарддаггүй, бас хориглодоггүй. Жишээлбэл; байгууллага нь УСНББОУС 29-ийн дагуу худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж ангилсан үүсмэл хэрэглүүрүүд ба уг худалдаа арилжааны багцаас гадуур эрсдлийн удирдлагын үйл ажиллагааны нэг хэсэг байдлаар ангилдаг үүсмэл хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тусад нь тодруулах сонголт хийж болно.

Түүнчлэн, ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөрийн дансны үнийг дараах байдлаар тусад нь харуулж, тодруулахыг УСНББОУС 30-ын 10-р параграфтаар шаарддаг: (i) анх

хүлээн зөвшөөрөхдөө ингэж сонгосон санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр, (ii) УСНББОУС 29-ийн дагуу худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж ангилсан санхүүгийн хөрөнгө буюу санхүүгийн өр төлбөр.

Ж.2 *УСНББОУС 29 ба УСНББОУС 2 - Хейжийн нягтлан бодох бүртгэл: Мөнгөн гүйлгээний тайлан*

**Хейжийн хэрэглүүрээс үүссэн мөнгөн гүйлгээг мөнгөн гүйлгээний тайланд хэрхэн ангилах вэ?**

Хейжийн хэрэглүүрүүдээс үүсэх мөнгөн гүйлгээг тухайн хейжийн зүйлээс үүсэх мөнгөн гүйлгээний ангилалд үндэслэн үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын ажиллагааны, санхүүгийн ажиллагааны гэж ангилдаг. УСНББОУС 29-ийг тусгахын тулд УСНББОУС 2-д заасан нэр томъёог шинэчлэн баяжуулаагүй байгаа боловч хейжийн хэрэглүүрээс үүсэх мөнгөн гүйлгээний тухайн мөнгөн гүйлгээний тайлан дахь ангилал нь УСНББОУС 29-ийн дагуу хейжийн хэрэглүүр гэж сонгосон тэдгээр хэрэглүүрийн ангилалтай нийцсэн байвал зохино.

## Үлгэрчилсэн жишээ

*Энэхүү үлгэрчилсэн жишээ нь УСНББОУС 29-ийг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.*

### **Хөрөнгө ба өр төлбөрийн багцад хүүний түвшний эрсдлийн хувьд хейж хийх**

- ҮЖ1. 20X1 оны 01 дүгээр сарын 01-нд А байгууллага нь хүүний түвшний эрсдэлд нь хейж хийхийг хүсэж буй хөрөнгүүд болон өр төлбөрүүдээс бүрдэх багцыг тодорхойлсон. Өр төлбөрүүд нь шаардсаны дагуу төлөх хадгаламжийн өр төлбөрийг агуулж байгаа бөгөөд түүний эзэмшигч нь урьдчилан мэдэгдэхгүйгээр хүссэн үедээ хадгаламжаа татаж болох юм. Эрсдлийн удирдлагын зорилгоор, байгууллага нь уг багц дахь бүх зүйлсийг тогтмол хүүтэй гэж үздэг.
- ҮЖ2. Эрсдлийн удирдлагын зорилгоор, А байгууллага нь хүлээгдэж буй дахин үнэ тогтоох өдрүүдэд үндэслэн уг багц дахь хөрөнгүүд болон өр төлбөрүүдийг тэдгээрийн дахин үнэ тогтоох хугацаагаар задлан шинжилдэг. Байгууллага нь сарын тайлант хугацааг ашигладаг бөгөөд зүйлсийг дараагийн таван жилээр (өөрөөр хэлбэл, сар тутмын 60 тусдаа тайлант үеэр) хуваарилдаг.<sup>22</sup> Уг багц дахь хөрөнгүүд нь урьдчилан төлж болох хөрөнгүүд бөгөөд А байгууллага нь тайлант үе бүрд бие даасан зүйлсийг биш, харин бүх хөрөнгийн хувийн жингээр хуваарилснаар тэдгээр хүлээгдэж буй урьдчилсан төлбөрийн өдрүүдэд үндэслэн тайлант үеүдэд хуваарилдаг. Мөн тус багц нь шаардсаны дагуу төлөх өр төлбөрийг агуулж байгаа бөгөөд багцад үндэслэн уг байгууллага нь тэдгээрийг нэг сараас таван жилийн хоорондох хугацаанд буцаан төлөхөөр хүлээж байна. Эрсдлийн удирдлагын зорилгоор тэдгээр өр төлбөрүүдийг энэ сууриар тайлант үеүдэд хуваарилна. А байгууллага нь тайлант үе бүрд хейж хийхийг хүсэж буй дүнг энэхүү шинжилгээнд үндэслэн шийдвэрлэнэ.
- ҮЖ3. Энэ жишээнд зөвхөн гурван сарын дараа дуусгавар болох тийм дахин үнэ тогтоох хугацааг, өөрөөр хэлбэл 20X1 оны 3 дугаар сарын 31-нд дуусгавар болох тайлант хугацааг авч үзсэн (үлдсэн 59 тайлант үе бүрд ижил горимыг хэрэглэнэ). А байгууллага нь энэ тайлант үед 100 сая ТН-ийн хөрөнгө ба 80 сая ТН-ийн өр төлбөрийг хуваарилсан. Бүх өр төлбөрийг шаардсаны дагуу төлж болох юм.
- ҮЖ4. Эрсдлийн удирдлагаар зорилгоор А байгууллага нь 20 сая ТН-ийн цэвэр төлөв байдалд хейж хийхээр шийдвэрлэсэн ба иймээс 20 сая ТН-ийн нэрлэсэн үндсэн дүнтэй, тогтмол хүү төлөх ба Лондонгийн Банк Хоорондын Санал Болгосон Хүү (LIBOR-ЛАЙБОР) авах, гурван сарын тогтмол

---

<sup>22</sup> Энэхүү жишээнд үндсэн дүнгийн мөнгөн гүйлгээг тайлант үеүдээр хуваарилсан боловч холбогдох хүүний мөнгөн гүйлгээг уг хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тооцоолох үедээ тусган оруулсан. Хөрөнгө, өр төлбөрийг хуваарилах бусад аргуудыг бас хэрэглэх боломжтой юм. Мөн энэ жишээнд сар тутам үнэ тогтоох тайлант үеийг ашигласан. Байгууллага нь арай богино эсвэл арай урт тайлант үеүдийг сонгож болно.

хугацаатай хүүний түвшний свопын<sup>23</sup> гэрээг 20X1 оны 01 дүгээр сарын 01-нд байгуулсан.

ҮЖ5. Энэ жишээнд дараах хялбаршуулсан төсөөллүүдийг хийсэн:

- (а) Свопын тогтмол хэсгийн купоны хүүний түвшин нь тухайн хөрөнгийн купоны тогтмол хүүний түвшинтэй тэнцүү байна;
- (б) Свопын тогтмол хэсгийн купоны хүүг тухайн хөрөнгийн хүүний төлбөрүүдийн өдөртэй ижил өдөр төлнө; ба
- (в) Свопын хувьсах хэсгийн хүүний түвшин нь нэг шөнийн ЛАЙБОР хүүний түвшинтэй тэнцүү байна. Иймээс свопын хувьсах хэсэг нь хүүний түвшний өөрчлөлтөөс хамаарсан бодит үнэ цэнийн өөрчлөлтийн эрсдэлд өртөхгүй учраас свопын бодит үнэ цэнийн нийт өөрчлөлт нь зөвхөн уг свопын тогтмол хэсгээс үүснэ.

Эдгээр хялбаршуулсан төсөөллүүд хэрэгжихгүй тохиолдолд илүү их үр дүнгүй байдал үүснэ. (Свопын тогтмол хэсэгтэй адилтгах тухайн хөрөнгийн мөнгөн гүйлгээний хэсгийг хейжийн зүйл гэж сонгосноор дээрх (а)-гаас үүсэх үр дүнгүй байдлыг арилгаж болно).

ҮЖ6. Мөн А байгууллага нь үр дүнгүй байдлын сорьж шалгана гэж төсөөлсөн.

ҮЖ7. Хейжийн тайлант үеийн турш дахь янз бүрийн хугацааны хүүний түвшний өөрчлөлтүүдэд хамааруулж болохгүй үнэ цэнийн өөрчлөлтийг харгалзаагүй 20 сая ТН-ийн дүнтэй, урьдчилан үл төлөх адилтгах хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дараах байдалтай байна:

	20X1.01.01	20X1.01.31	20X1.02.01	20X1.02.28	20X1.3.31
<b>Бодит үнэ цэнэ (хөрөнгө) (ТН)</b>	20,000,000	20,047,408	20,047,408	20,023,795	Тэг

ҮЖ8. Хейжийн тайлант үеийн турш дахь янз бүрийн хугацааны свопын бодит үнэ цэнэ нь дараах байдалтай байна:

	20X1.01.01	20X1.01.31	20X1.02.01	20X1.02.28	20X1.3.31
<b>Бодит үнэ цэнэ (өр төлбөр) (ТН)</b>	Тэг	(47,408)	(47,408)	(23,795)	Тэг

### Нягтлан бодох бүртгэлийн арга хандлага

ҮЖ9. 20X1 оны 01 дүгээр сарын 01-нд А байгууллага нь 20 сая ТН-ийн дүнтэй хөрөнгийг гурван сарын хугацаанд хейжийн зүйл гэж сонгосон. Тус байгууллага нь ЛАЙБОР-ын өөрчлөлтөнд хамааруулж болох уг хейжийн зүйлийн (өөрөөр хэлбэл, 20 сая ТН-ийн дүнтэй хөрөнгийн) бодит үнэ цэнийн

<sup>23</sup> Энэ жишээнд хейжийн хэрэглүүр болгон свопыг ашигласан. Хейжийн хэрэглүүр болгон уг байгууллага нь форвард хүүний гэрээ буюу бусад үүсмэл хэрэглүүрийг ашиглаж болно.

өөрчлөлтийг хейж хийсэн эрсдэл гэж сонгосон. Мөн уг байгууллага нь энэ Стандартын 98(г) параграф болон МЗУ162-р параграфт заасан, хейжийн сонголтын бусад шаардлагуудыг даган мөрдсөн.

ҮЖ10. А байгууллага нь ҮЖ4-р параграфт дурдсан, хүүний түвшний свопыг хейжийн хэрэглүүр гэж сонгосон.

*1 дэх сарын эцэст (20Х1 оны 01 дүгээр сарын 31)*

ҮЖ11. 20Х1 оны 01 дүгээр сарын 31-нд (1 дэх сарын эцэст) А байгууллага нь үр дүнтэй байдлыг сорьж шалгах үед ЛАЙБОР хүү буурсан байв. Үүний улмаас урьдчилсан төлбөрийг өмнө тооцоолж байснаас илүү хурдан хийнэ гэж А байгууллага нь урьдчилсан төлбөрийн түүхэн туршлагад үндэслэн тооцоолсон. Иймээс уг байгууллага нь энэхүү тайлант үед хуваарилсан хөрөнгийн дүнг (тухайн сарын туршид бий болсон шинэ хөрөнгүүдийг оруулахгүй) 96 сая ТН гэж дахин тооцоолсон.

ҮЖ12. 20 сая ТН-ийн нэрлэсэн үндсэн дүнтэй, уг сонгосон хүүний түвшний свопын бодит үнэ цэнэ нь (47,408 ТН)<sup>24</sup> (своп нь өр төлбөр) байна.

ҮЖ13. Тооцоолсон урьдчилсан төлбөрүүдийн өөрчлөлтийг харгалзсанаар А байгууллага нь уг хейжийн зүйлийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг дараах байдлаар тооцоолсон.

(а) Нэгдүгээрт, байгууллага нь хейж хийсэн тухайн тайлант үеийн хувьд уг хөрөнгийн анхны тооцооллын хувийн жинг тооцоолсон. Энэ нь 20 хувь (20 сая ТН : 100 сая ТН) байна.

(б) Хоёрдугаарт, байгууллага нь өөрийн хянан засварласан тооцоололд үндэслэсэн хейжийн зүйлийн дүнг тооцохын тулд тухайн тайлант үед уг дүнгийн хянан засварласан тооцооллыг (96 сая ТН) энэхүү хувийн жингээр (20 хувиар) үржүүлнэ. Энэ нь 19.2 сая ТН байна.

(в) Гуравдугаарт, байгууллага нь ЛАЙБОР-ын өөрчлөлтөнд хамааруулж болох уг хейжийн зүйлийн энэхүү хянан засварласан тооцооллын (19.2 сая ТН) бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тооцоолно. Энэ нь 45,511 ТН (47,408 ТН<sup>25</sup> х (19.2 сая ТН : 20 сая ТН)) байна.

ҮЖ14. А байгууллага нь энэхүү тайлант үед дараах нягтлан бодох бүртгэлийн бичилтүүдийг хийнэ:

Дебит	Мөнгө	172,097 ТН
Кредит	Ашиг, алдагдал (хүүний орлого) <sup>26</sup>	172,097 ТН

*Уг хейж хийсэн дүнгээс хүлээн авсан хүүг (19.2 сая ТН) хүлээн зөвшөөрөх.*

<sup>24</sup> ҮЖ8-р параграфыг үзнэ үү.

<sup>25</sup> Өөрөөр хэлбэл, 20,047,408 ТН-20,000,000 ТН, ҮЖ7-р параграфыг үзнэ үү.

<sup>26</sup> Хүүний орлого ба хүүний зардлын дүнг хэрхэн тооцоолсныг энэ жишээнд харуулаагүй.

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

Дебит	Ашиг, алдагдал (хүүний зардал)	179,268 ТН	
Кредит	Ашиг, алдагдал (хүүний орлого)		179,268 ТН
Кредит	Мөнгө		0 ТН

*Хейжийн хэрэглүүр гэж сонгосон свопын хувьд хүлээн авсан ба төлсөн хүүг хүлээн зөвшөөрөх.*

Дебит	Ашиг, алдагдал (гарз)	47,408 ТН	
Кредит	Үүсмэл өр төлбөр		47,408 ТН

*Свопын бодит үнэ цэнийн өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөх.*

Дебит	Санхүүгийн байдлын тайлан дахь тусдаа мөрийн зүйл	45,511 ТН	
Кредит	Ашиг, алдагдал (олз)		45,511 ТН

*Уг хейж хийсэн дүнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөх.*

ҮЖ15. Ашиг, алдагдалд тусгах цэвэр үр дүн (хүүний орлого ба хүүний зардлыг оруулахгүйгээр) нь (1,897 ТН)-ийн гарзыг хүлээн зөвшөөрөх явдал юм. Энэ нь тооцоолсон урьдчилсан төлбөрийн өдрүүдийн өөрчлөлтөөс үүсэх хейжийн харилцааны үр дүнгүй байдлыг илэрхийлнэ.

**2 дахь сарын эхэнд**

ҮЖ16. 20X1 оны 2 дугаар сарын 01-нээр А байгууллага нь хөрөнгийн тодорхой хэсгийг янз бүрийн хугацаанд борлуулсан байв. А байгууллага нь хөрөнгийн нийт багцын  $8\frac{1}{3}$  хувийг борлуулсан гэж тооцоолсон. Тайлант үе бүрд хөрөнгүүдийг хувийн жингээр (бие даасан хөрөнгүүдээр биш) хуваарилж, тайлант үеүдэд хамруулдаг учраас А байгууллага нь тухайн борлуулсан хөрөнгүүд аль тайлант үед хамрагдахыг тодорхойлох боломжгүй гэж үзсэн. Иймээс тус байгууллага нь хуваарилалтын системчилсэн ба ул үндэслэлтэй суурийг ашигладаг. Багц дахь хөрөнгүүдийн төлөөлөл болох сонгосон хэсгийг борлуулдаг гэсэн үндэслэлээр А байгууллага нь уг борлуулалтыг нийт тайлант үеүдэд хувь тэнцүүлэн хуваарилна.

ҮЖ17. Энэ үндэслэлээр А байгууллага нь уг гурван сарын тайлант үед хуваарилсан хөрөнгүүдийн  $8\frac{1}{3}$  хувийг, өөрөөр хэлбэл 8 сая ТН-ийг (96 сая ТН-ийн  $8\frac{1}{3}$  хувийг) борлуулсан гэж тооцоолсон. Хүлээн авсан мөнгөн орлого нь тухайн хөрөнгийн бодит үнэ цэнэтэй тэнцүү буюу 8,018,400 ТН байна.<sup>27</sup> Хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх үед А байгууллага нь одоо борлуулсан уг хейж хийж байсан хөрөнгүүдийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг илэрхийлэх дүнг тухайн санхүүгийн байдлын тайлан дахь тусдаа мөрийн зүйлээс бас

<sup>27</sup> Хөрөнгийн борлуулалтаар хүлээн зөвшөөрсөн дүн нь урьдчилан төлж болох хөрөнгийн бодит үнэ цэнэ байна. Энэ нь ҮЖ7-д харуулсан урьдчилан төлж болохгүй адилтгах хөрөнгийн бодит үнэ цэнээс бага байна.

хасна. Энэ нь уг мөрийн зүйлийн 45,511 ТН-ийн нийт үлдэгдлийн  $8\frac{1}{3}$  хувь, өөрөөр хэлбэл 3,793 ТН байна.

ҮЖ18. А байгууллага нь хөрөнгийн борлуулалт ба санхүүгийн байдлын тайлан дахь тусдаа мөрийн зүйлийн үлдэгдлийн зарим хэсгийн хасалтыг хүлээн зөвшөөрөхийн тулд дараах нягтлан бодох бүртгэлийн бичилтүүдийг хийнэ:

Дебит	Мөнгө	8,018,400 ТН	
Кредит	Хөрөнгө		8,000,000 ТН
Кредит	Санхүүгийн байдлын тайлан дахь тусдаа мөрийн зүйл		3,793 ТН
Кредит	Ашиг, алдагдал (олз)		14,607 ТН

*Хөрөнгийн борлуулалтыг бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх ба борлуулалтын олзыг хүлээн зөвшөөрөх.*

Хөрөнгүүдийн дүнгийн өөрчлөлтийг уг хейж хийсэн хүүний түвшний өөрчлөлтөнд хамааруулж болохгүй учраас үр дүнгүй байдал үүсэхгүй.

ҮЖ19. Энэхүү тайланд үед А байгууллага нь одоогоор 88 сая ТН-ийн хөрөнгөтэй, 80 сая ТН-ийн өр төлбөртэй байна. Иймээс А байгууллагын хейж хийхийг хүсэж буй цэвэр дүн нь одоо 8 сая ТН байгаа бөгөөд иймээс хейж хийсэн дүн гэж 8 сая ТН-ийг сонгоно.

ҮЖ20. А байгууллага нь анхны свопын зөвхөн тодорхой хэсгийг хейжийн хэрэглүүр гэж сонгосноор уг хейжийн хэрэглүүрийг тохируулахаар шийдвэрлэсэн. Иймээс тус байгууллага нь хоёр сарын дуусгавар болох үлдсэн хугацаатай, анхны свопын нэрлэсэн дүнгийн 8 сая ТН буюу 40 хувь, 18,963 ТН<sup>28</sup>-ийн бодит үнэ цэнэтэй хэсгийг хейжийн хэрэглүүр гэж сонгосон. Мөн байгууллага нь Стандартын 98(а) параграф болон МЗУ162-р параграфт заасан, хейжийн сонголтын бусад шаардлагуудыг даган мөрдсөн. Хейжийн хэрэглүүр гэж цаашид сонгохгүй, уг свопын нэрлэсэн дүнгийн 12 сая ТН-ийг түүний бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрснөөр худалдаа арилжааны зорилгоор эзэмшиж буй гэж ангилна эсвэл өөр хейжид хейжийн хэрэглүүр гэж сонгоно.<sup>29</sup>

ҮЖ21. 20Х1оны 2 дугаар сарын 01-нээр буюу тухайн хөрөнгийн борлуулалтыг тайлагнасны дараа, уг санхүүгийн байдлын тайлан дахь тусдаа мөрийн зүйл нь 41,718 ТН (45,511 ТН – 3,793 ТН) болох бөгөөд энэ нь 17.6 сая ТН<sup>30</sup>-ийн хөрөнгийн бодит үнэ цэнийн хуримтлагдсан өөрчлөлтийг илэрхийлнэ. Гэвч 20Х1 оны 02 дугаар сарын 01-ний байдлаар А байгууллага нь 18,963 ТН<sup>31</sup>-ийн бодит үнэ цэнийн хуримтлагдсан өөрчлөлт бүхий ердөө 8 сая ТН-

<sup>28</sup> 47,408 ТН х 40 хувь.

<sup>29</sup> Эсвэл байгууллага нь өөрийн төлөв байдлыг тохируулах ба одоо байгаа свопын нийт 20 сая ТН-ийг болон харилцан нөхөх шинэ свопын нийт 12 сая ТН-ийг хейжийн хэрэглүүр гэж сонгохын тулд 12 сая ТН-ийн нэрлэсэн дүн бүхий харилцан нөхөх свопын гэрээ байгуулж болно.

<sup>30</sup> 19.2 сая ТН – ( $8\frac{1}{3}$  х 19.2 сая ТН).

<sup>31</sup> 41,718 ТН х (8 сая ТН/17.6 сая ТН)

ийн хөрөнгөнд хейж хийж байна. Санхүүгийн байдлын тайланд үлдсэн 22,755 ТН<sup>32</sup>-ийн тусдаа мөрийн зүйл нь А байгууллага одоо ч эзэмшсээр байгаа боловч хейж хийхээ больсон хөрөнгүүдийн дүнг илэрхийлнэ. Иймээс А байгууллага нь энэхүү дүнг тухайн тайлант үеийн үлдсэн хугацаанд хорогдуулна. Өөрөөр хэлбэл, 22,755 ТН-ийг хоёр сарын хугацаанд хорогдуулна.

ҮЖ22. А байгууллага нь уг дахин тооцоолсон үр ашигт өгөөжид үндэслэсэн хорогдуулгын аргыг ашиглах практик боломжгүй гэж үзсэн ба иймээс шулуун шугамын аргыг ашигласан.

*2 дахь сарын эцэст (20X1 оны 02 дугаар сарын 28)*

ҮЖ23. 20X1оны 02 дугаар сарын 28-нд, А байгууллага нь үр дүнтэй байдлыг дараагийн удаа сорьж шалгахад ЛАЙБОР хүү өөрчлөгдөөгүй байсан. А байгууллага нь өөрийн урьдчилсан төлбөрийн хүлээлтийг засварлан өөрчлөөгүй. 8 сая ТН-ийн нэрлэсэн үндсэн дүнтэй, уг хейж хийхээр сонгосон хүүний түвшний свопын бодит үнэ цэнэ нь (9,518 ТН)<sup>33</sup> байсан (уг своп нь өр төлбөр юм). Мөн А байгууллага нь уг хейж хийсэн 8 сая ТН-ийн хөрөнгүүдийн бодит үнэ цэнийг 20X1 оны 2 дугаар сарын 28-ны байдлаар 8,009,518 ТН<sup>34</sup> гэж тооцоолсон.

ҮЖ24. А байгууллага нь энэхүү тайлант үед уг хейжтэй холбоотойгоор дараах нягтлан бодох бүртгэлийн бичилтийг хийнэ:

Дебит	Мөнгө	71,707 ТН	
	Кредит	Ашиг, алдагдал (хүүний орлого)	71,707 ТН

*Уг хейж хийсэн дүнгээс хүлээн авсан хүүг (8 сая ТН) хүлээн зөвшөөрөх.*

Дебит	Ашиг, алдагдал (хүүний зардал)	71,707 ТН	
	Кредит	Ашиг, алдагдал (хүүний орлого)	62,115 ТН
	Кредит	Мөнгө	9,592 ТН

*Хейжийн хэрэглүүр гэж сонгосон свопын (8 сая ТН) хувьд хүлээн авсан ба төлсөн хүүг хүлээн зөвшөөрөх.*

Дебит	Үүсмэл өр төлбөр	9,445 ТН	
	Кредит	Ашиг, алдагдал (олз)	9,445 ТН

*Хейжийн хэрэглүүр гэж сонгосон свопын (8 сая ТН) хэсгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг (9,518 ТН – 18,963 ТН) хүлээн зөвшөөрөх.*

<sup>32</sup> 41,718 ТН – 18,963 ТН.

<sup>33</sup> 23,795 ТН [ҮЖ8-р параграфыг үзнэ үү] x (8 сая ТН/20 сая ТН).

<sup>34</sup> 20,023,795 ТН [ҮЖ7-р параграфыг үзнэ үү] x (8 сая ТН/20 сая ТН).



САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

Дебит	Ашиг, алдагдал (гарз)	9,445 ТН	
Кредит	Санхүүгийн байдлын тайлан дахь тусдаа мөрийн зүйл		9,445 ТН

*Уг хейж хийсэн дүнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг (8,009,518 ТН – 8,018,963 ТН) хүлээн зөвшөөрөх.*

ҮЖ25. Ашиг, алдагдалд үзүүлэх (хүүний орлого ба хүүний зардлыг оруулаагүй) цэвэр үр нөлөө нь тэг (0) бөгөөд уг хейж бүрэн үр дүнтэй байгааг илэрхийлнэ.

ҮЖ26. А байгууллага нь уг мөрийн зүйлийн үлдэгдлийг энэхүү тайлант үед хорогдуулахын тулд дараах нягтлан бодох бүртгэлийн бичилтийг хийнэ:

Дебит	Ашиг, алдагдал (гарз)	11,378 ТН	
Кредит	Санхүүгийн байдлын тайлан дахь тусдаа мөрийн зүйл		11,378 ТН <sup>(a)</sup>

*Тухайн тайлант үеийн хорогдуулгын зардлыг хүлээн зөвшөөрөх.*

<sup>(a)</sup> 22,755 : 2

**3 дахь сарын эцэст**

ҮЖ27. Гурван сарын хугацаатай хөрөнгө буюу өр төлбөрийн дүнд гурав дахь сарын туршид цаашид өөрчлөлт ороогүй. 20X1оны 3 дугаар сарын 31-нд тухайн хөрөнгийн болон свопын хугацаа дуусгавар болж байгаа бөгөөд бүх үлдэгдлийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

ҮЖ28. А байгууллага нь энэхүү тайлант үетэй холбоотойгоор дараах нягтлан бодох бүртгэлийн бичилтийг хийнэ:

Дебит	Мөнгө	8,071,707 ТН	
Кредит	Хөрөнгө (санхүүгийн байдлын тайлан)		8,000,000 ТН
Кредит	Ашиг, алдагдал (хүүний орлого)		71,707 ТН

*Уг хейж хийсэн дүнгийн (8 сая ТН) хугацаа дууссанаар хүлээн авсан мөнгө ба хүүг хүлээн зөвшөөрөх.*

Дебит	Ашиг, алдагдал (хүүний зардал)	71,707 ТН	
Кредит	Ашиг, алдагдал (хүүний орлого)		62,115 ТН
Кредит	Мөнгө		9,592 ТН

*Хейжийн хэрэглүүр гэж сонгосон свопын (8 сая ТН) тодорхой хэсгийн хувьд хүлээн авсан ба төлсөн хүүг хүлээн зөвшөөрөх.*

Дебит	Үүсмэл өр төлбөр	9,518 ТН	
Кредит	Ашиг, алдагдал (олз)		9,518 ТН

*Хейжийн хэрэглүүр гэж сонгосон свопын (8 сая ТН) тодорхой хэсгийн хугацаа дуусалтыг хүлээн зөвшөөрөх.*

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

Дебит	Ашиг, алдагдал (гарз)	9,518 ТН	
Кредит	Санхүүгийн байдлын тайлан дахь тусдаа мөрийн зүйл		9,518 ТН

*Үлдсэн мөрийн зүйлийн үлдэгдлийг тухайн хугацаа дуусгавар болсноор данснаас хасах.*

ҮЖ29. Ашиг, алдагдалд үзүүлэх (хүүний орлого ба хүүний зардлыг оруулаагүй) цэвэр үр нөлөө нь тэг (0) бөгөөд уг хейж бүрэн үр дүнтэй байгааг илэрхийлнэ.

ҮЖ30. А байгууллага нь уг мөрийн зүйлийн үлдэгдлийг энэхүү тайлант үед хорогдуулахын тулд дараах нягтлан бодох бүртгэлийн бичилтийг хийнэ:

Дебит	Ашиг, алдагдал (гарз)	11,377 ТН	
Кредит	Санхүүгийн байдлын тайлан дахь тусдаа мөрийн зүйл		11,377 ТН <sup>(a)</sup>

*Тухайн тайлант үеийн хорогдуулгын зардлыг хүлээн зөвшөөрөх.*

<sup>(a)</sup> 22,755 : 2

### Хураангуй

ҮЖ31. Доорх хүснэгтэнд дараах зүйлсийг хураангуйлан харуулав:

- (a) Санхүүгийн байдлын тайлан дахь тусдаа мөрийн зүйлийн өөрчлөлт;
- (б) Үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнэ;
- (в) Хейжийн нийт гурван сарын хугацаан дахь уг хейжийн ашиг, алдагдлын үр нөлөө; ба
- (г) Хейж хийсэн гэж сонгосон дүнд хамаарах хүүний орлого ба хүүний зардал.

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

Утга	20X1.01.01 ТН	20X1.01.31 ТН	20X1.02.01 ТН	20X1.02.28 ТН	20X1.3.31 ТН
<b>Хейж хийсэн хөрөнгийн дүн</b>	<b>20,000,000</b>	<b>19,200,000</b>	<b>8,000,000</b>	<b>8,000,000</b>	<b>8,000,000</b>
<b>(а) Санхүүгийн байдлын тайлан дахь тусдаа мөрийн зүйлийн өөрчлөлт</b>					
Өмнөх үеэс шилжиж ирсэн:					
Хорогдуулах үлдэгдэл	Тэг	Тэг	Тэг	22,755	11,377
Үлдэж буй үлдэгдэл	Тэг	Тэг	45,511	18,963	9,518
Хасах: Хөрөнгийн борлуулалтын тохируулга	Тэг	Тэг	(3,793)	Тэг	Тэг
Хейж хийсэн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн тохируулга	Тэг	45,511	Тэг	(9,445)	(9,518)
Хорогдуулга	Тэг	Тэг	Тэг	(11,378)	(11,377)
<b>Дараагийн үед шилжүүлэх:</b>					
Хорогдуулах үлдэгдэл	Тэг	Тэг	<b>22,755</b>	<b>11,377</b>	Тэг
Үлдэж буй үлдэгдэл	Тэг	<b>45,511</b>	<b>18,963</b>	<b>9,518</b>	Тэг
<b>(б) Үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнэ</b>					
20,000,000 ТН	Тэг	47,408	-	Хейжийн хэрэглүүр гэж цаашид сонгохгүй.	
12,000,000 ТН	Тэг	-	28,445		
8,000,000 ТН	Тэг	-	18,963	9,518	Тэг
<b>Нийт дүн</b>	<b>Тэг</b>	<b>47,408</b>	<b>47,408</b>	<b>9,518</b>	<b>Тэг</b>
<b>(в) Ашиг, алдагдалд хейжийн үзүүлэх үр нөлөө</b>					
Мөрийн зүйлийн өөрчлөлт: хөрөнгө	Тэг	45,511	Хамаа/гүй	(9,445)	(9,518)
Үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	Тэг	(47,408)	Хамаа/гүй	9,445	9,518
<b>Цэвэр үр нөлөө</b>	<b>Тэг</b>	<b>(1,897)</b>	<b>Хамаа/гүй</b>	<b>Тэг</b>	<b>Тэг</b>
<b>Хорогдуулга</b>	<b>Тэг</b>	<b>Тэг</b>	<b>Хамаа/гүй</b>	<b>(11,378)</b>	<b>(11,377)</b>
Түүнчлэн, 20X1 оны 2-р сарын 01-нд хөрөнгийн борлуулалтын 14,607 ТН-ийн олз байна.					
<b>(г) Хейж хийсэн гэж сонгосон уг дүнд хамаарах хүүний орлого ба хүүний зардал</b>					
<b>Хүүний орлого</b>					
- хөрөнгийн	Тэг	172,097	Хамаа/гүй	71,707	71,707
- свопын	Тэг	179,268	Хамаа/гүй	62,115	62,115
<b>Хүүний зардал</b>					
- свопын	Тэг	(179,268)	<b>Хамаа/гүй</b>	(71,707)	(71,707)

### Гадаад үйл ажиллагааны данснаас хасалт

ҮЖ32. Гадаад үйл ажиллагааны данснаас хасалтаар ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн дүнтэй холбоотойгоор Хавсралт В-гийн В12 ба В13-р параграфыг хэрхэн мөрдөхийг энэ жишээнд үлгэрчлэн харуулсан.

#### *Танилцуулга*

ҮЖ33. Энэ жишээний хувьд уг эдийн засгийн байгууллага нь Мөрдөх заавар удирдамжид тусгасантай адил бүтэцтэй бөгөөд Г байгууллага нь өөрийн нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь В байгууллагад оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын Доллар/Евроны эрсдэлд хейж хийхийн тулд А байгууллага дахь ам долларын зээлийг ашигласан гэж үзье. Г байгууллага нь алхам-алхамаар нэгтгэх аргыг ашигладаг. Хейж нь бүрэн үр дүнтэй бөгөөд В байгууллагыг данснаас хасахын өмнөх уг хейжийн хэрэглүүрийн үнэ цэнийн Доллар/Евроны хуримтлагдсан нийт өөрчлөлт нь 24 сая € (олз) байна. Г байгууллагын бүртгэлийн валюттай (евро) харьцуулан хэмжихэд энэ нь В байгууллагад оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралттай яг уялдаж байсан.

ҮЖ34. Хэрэв нэгтгэлийн шууд аргыг ашигласан бол В байгууллагад оруулсан Г байгууллагын цэвэр хөрөнгө оруулалтын үнэ цэнийн 24 сая €-ны бууралтыг уг Г байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь В байгууллагатай холбоотой гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцөд бүхэлд нь тусгах байсан. Гэвч Г байгууллага нь алхам-алхамаар нэгтгэх аргыг ашигладаг учраас В байгууллагад оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын энэхүү 24 сая €-ны бууралтыг В байгууллагатай холбоотойгоор Б байгууллагын гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц болон Б байгууллагатай холбоотойгоор Г байгууллагын гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцийн аль алинд тусгана.

ҮЖ35. Б болон В байгууллагуудтай холбоотойгоор гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцөд хүлээн зөвшөөрсөн нэгтгэсэн дүнд уг нэгтгэлийн арга нөлөө үзүүлэхгүй. Нэгтгэлийн шууд аргыг ашиглана гэж үзвэл Г байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь Б болон В байгууллагуудын гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцүүд нь харгалзан 62 сая €-ны олзтой ба 24 сая €-ны гарзтай байна; харин алхам-алхамаар нэгтгэх аргыг ашиглавал, эдгээр дүнгүүд нь харгалзан 49 сая €-ны олзтой ба 11 сая €-ны гарзтай байна.

#### *Дахин ангилал*

ҮЖ36. В байгууллагад оруулсан хөрөнгө оруулалтыг данснаас хассан тохиолдолд уг хейжийн хэрэглүүрийн нийт 24 сая €-ны олзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөхийг УСНББОУС 29-өөр шаардана. Алхам-алхамаар нэгтгэх аргыг ашиглавал В байгууллагад оруулсан цэвэр хөрөнгө оруулалтын хувьд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх дүн нь ердөө 11 сая €-ны гарз байна. Г байгууллага нь нэгтгэлийн шууд аргыг ашигласан ба энэ нь түүний нягтлан бодох бүртгэлийн бодлого байсан бол уг хейжийн хэрэглүүр болон цэвэр хөрөнгө оруулалтын хувьд дахин ангилах дүнгүүдтэй уялдуулахын

тулд Б ба В байгууллагын аль алины гадаад валютын хөрвүүлэлтийн нөөцүүдийг 13 сая €-гоор тохируулж болох юм. Өөрийн цэвэр хөрөнгө оруулалтанд хейж хийгээгүй байгууллага нь ийм дахин ангиллыг хийж болно.

### Хөнгөлөлттэй зээлийн мөнгөн орлого

ҮЖ37. Орон нутгийн захиргааны байгууллага нь 5 жилийн хугацаанд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүлэх эмнэлэг барихын тулд олон улсын хөгжлийн агентлагаас 5 сая ТН-ийн зээлийн санхүүжилтийг хүлээн авсан. Уг зээлийг 5 жилийн хугацаанд дараах байдлаар буцаан төлнө гэж зээлийн гэрээнд заасан:

Жил 1: Үндсэн зээлээс буцаан төлөхгүй  
 Жил 2: Үндсэн зээлийн 10 хувь  
 Жил 3: Үндсэн зээлийн 20 хувь  
 Жил 4: Үндсэн зээлийн 30 хувь  
 Жил 5: Үндсэн зээлийн 40 хувь

Төлөгдөөгүй зээлийн үлдэгдлээс жилийн 5 хувиар тооцож, хүүг жил бүр төлнө. Ижил төсөөтэй ажил гүйлгээний зах зээлийн холбогдох хүүний түвшин нь 10 хувь байсан.

ҮЖ38. Байгууллага нь 5 сая ТН-ийн хөнгөлөлттэй зээл авсан бөгөөд одоогийн зах зээлийн хүүний түвшнээс бага буюу 5 хувийн хүүтэйгээр уг зээлийг буцаан төлнө. Зах зээлийн хүүний түвшинг ашиглан дискаунтчилсан, уг зээлийн гэрээний нөхцлүүдийн дагуу төлөх гэрээний төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнэ ба зээлийн мөнгөн орлогын хоорондох зөрүүг арилжааны бус орлого гэж хүлээн зөвшөөрнө.

ҮЖ39. Хөнгөлөлттэй зээлийг бүртгэх журналын бичилт нь дараах байдалтай байна:

1. Анх хүлээн зөвшөөрөх үед байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө (байгууллага нь хөнгөлөлттэй зээлийг дараагийн тайлант үед хорогдуулсан өртгөөр хэмждэг гэж үзсэн):

Дебит	Харилцах данс	5,000,000 ТН	
Кредит	Зээлийн өглөг (доорх Хүснэгт 2-ыг үз)		4,215,450 ТН
Кредит	Өр төлбөр эсвэл арилжааны бус орлого		784,550 ТН

*Зээлийн мөнгөн орлогыг бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх.*

*Зээлийн зах зээлийн бус хэсгийг өр төлбөр эсвэл орлого гэж хүлээн зөвшөөрөхдөө УСНББОУС 23-ыг харгалзан үзнэ. Арилжааны бус орлого гэж үзэх уг зээлийн зах зээлийн бус хэсгийн хүлээн зөвшөөрөлт ба*

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

хэмжилтийн журналын бичилтүүдийг тэрхүү Стандартын ХЗУ54-р параграфт харуулсан.

2. Жил 1: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Хүүний зардал (доорх Хүснэгт 3-ыг үз)	421,545 ТН	
Кредит	Зээлийн өглөг		421,545 ТН

*Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (4,215,450 ТН x 10%) хүлээн зөвшөөрөх.*

Дебит	Зээлийн өглөг (доорх Хүснэгт 1-ийг үз)	250,000 ТН	
Кредит	Харилцах данс		250,000 ТН

*Төлөгдөөгүй үлдээглээс тооцож, төлсөн хүүг (5 сая ТН x 5%) хүлээн зөвшөөрөх.*

3. Жил 2: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Хүүний зардал	438,700 ТН	
Кредит	Зээлийн өглөг		438,700 ТН

*Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (4,386,995 ТН x 10%) хүлээн зөвшөөрөх.*

Дебит	Зээлийн өглөг	750,000 ТН	
Кредит	Харилцах данс		750,000 ТН

*Төлөгдөөгүй үлдээглээс тооцож, төлсөн хүүг (5 сая ТН x 5% + буцаан төлсөн үндсэн дүн 500,000 ТН) хүлээн зөвшөөрөх.*

4. Жил 3: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Хүүний зардал	407,569 ТН	
Кредит	Зээлийн өглөг		407,569 ТН

*Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (4,075,695 ТН x 10%) хүлээн зөвшөөрөх.*

Дебит	Зээлийн өглөг	1,225,000 ТН	
Кредит	Харилцах данс		1,225,000 ТН

*Төлөгдөөгүй үлдээглээс тооцож, төлсөн хүүг (4.5 сая ТН x 5% + буцаан төлсөн үндсэн дүн 1.0 сая ТН) хүлээн зөвшөөрөх.*

5. Жил 4: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Хүүний зардал	325,826 ТН	
Кредит	Зээлийн өглөг		325,826 ТН

*Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (3,258,264 ТН x 10%) хүлээн зөвшөөрөх.*

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

Дебит	Зээлийн өглөг	1,675,000 ТН	
Кредит	Харилцах данс		1,675,000 ТН

*Төлөгдөөгүй үлдэгдлээс тооцож, төлсөн хүүг (3.5 сая ТН х 5% + буцаан төлсөн үндсэн дүн 1.5 сая ТН) хүлээн зөвшөөрөх.*

6. Жил 5: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Хүүний зардал	190,909 ТН	
Кредит	Зээлийн өглөг		190,909 ТН

*Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (1,909,091 ТН х 10%) хүлээн зөвшөөрөх.*

Дебит	Зээлийн өглөг	2,100,000 ТН	
Кредит	Харилцах данс		2,100,000 ТН

*Төлөгдөөгүй үлдэгдлээс тооцож, төлсөн хүүг (2.0 сая ТН х 5% + буцаан төлсөн үндсэн дүн 2.0 сая ТН) хүлээн зөвшөөрөх.*

Тооцоолол:

**Хүснэгт 1: Хорогдуулгын хуваарь (5 хувийн хүүтэй гэрээний эргэн төлөлтийг ашиглах)**

	Жил 0 ТН	Жил 1 ТН	Жил 2 ТН	Жил 3 ТН	Жил 4 ТН	Жил 5 ТН
Үндсэн дүн	5,000,000	5,000,000	5,000,000	4,500,000	3,500,000	2,000,000
Хүү	-	250,000	250,000	225,000	175,000	100,000
Төлөлт	-	(250,000)	(750,000)	(1,225,000)	(1,675,000)	(2,100,000)
<b>Үлдэгдэл</b>	<b>5,000,000</b>	<b>5,000,000</b>	<b>4,500,000</b>	<b>3,500,000</b>	<b>2,000,000</b>	

**Хүснэгт 2: Гэрээний мөнгөн гүйлгээг дискаунтчлах (10 хувийн зах зээлийн хүүнд үндэслэсэн)**

	Жил 1 ТН	Жил 2 ТН	Жил 3 ТН	Жил 4 ТН	Жил 5 ТН
Үндсэн дүнгийн үлдэгдэл	5,000,000	4,500,000	3,500,000	2,000,000	-
Хүүний өглөг	250,000	250,000	225,000	175,000	100,000
Нийт төлөлт (үндсэн дүн ба хүү)	250,000	750,000	1,225,000	1,675,000	2,100,000
Төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнэ	227,272	619,835	920,360	1,144,048	1,303,935
Төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнүүдийн нийт дүн					<u>4,215,450</u>
Хүлээн авсан мөнгөн орлого					5,000,000
Хасах: Мөнгөн зарлагын өнөөгийн үнэ цэнэ (анх хүлээн зөвшөөрөх үеийн зээлийн бодит үнэ цэнэ)					<u>4,215,450</u>
Арилжааны бус орлого гэж хүлээн зөвшөөрөх уг зээлийн зах зээлийн бус хэсэг					<u>784,550</u>

**Хүснэгт 3: Үр ашигт хүүний аргыг ашиглан зээлийн үлдэгдэл ба хүүг тооцоолох**

	Жил 1 ТН	Жил 2 ТН	Жил 3 ТН	Жил 4 ТН	Жил 5 ТН
Үндсэн дүн	4,215,450	4,386,995	4,075,695	3,258,264	1,909,091
Хүүний хуримтлуулалт	421,545	438,700	407,569	325,827	190,909
Хүү ба үндсэн дүнгийн төлөлт	250,000	750,000	1,225,000	1,675,000	2,100,000
<b>Үлдэгдэл</b>	<b>4,386,995</b>	<b>4,075,695</b>	<b>3,258,264</b>	<b>1,909,091</b>	<b>-</b>

**Хөнгөлөлттэй зээлийн төлөлт**

ҮЖ40. Дээд боловсролыг дэмжих арга хэрэгсэл болгон Боловсролын яам нь зохих шалгуур хангасан оюутнуудад бага хүүтэй зээлийг эргэн төлөх уян хатан нөхцөлтэйгээр олгодог.

ҮЖ41. Яам нь тухайн санхүүгийн жилийн эхэнд дараах нөхцөл, болзолтойгоор 250 сая ТН-ийн зээлийг янз бүрийн оюутнуудад урьдчилан олгосон.

- Үндсэн дүнг дараах байдлаар төлнө:  
Жил 1-ээс 3: үндсэн дүнгээс буцаан төлөхгүй  
Жил 4: үндсэн дүнгийн 30 хувийг буцаан төлнө  
Жил 5: үндсэн дүнгийн 30 хувийг буцаан төлнө  
Жил 6: үндсэн дүнгийн 40 хувийг буцаан төлнө
- Хүүг тухайн зээлийн төлөгдөөгүй үлдэгдлээс жилийн 6 хувиар тооцож, жил бүр төлнө. Ижил төсөөтэй зээлийн хүүний зах зээлийн түвшин нь 11.5 хувь байсан гэж үзье.

ҮЖ42. Хөнгөлөлттэй зээлийг бүртгэх журналын бичилт нь дараах байдалтай байна (байгууллага нь хөнгөлөлттэй зээлийг дараагийн тайлант үед хорогдуулсан өртгөөр хэмждэг гэж үзсэн):

1. Анх хүлээн зөвшөөрөх үед байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Зээлийн авлага	199,345,480 ТН	
Дебит	Зардал	50,654,520 ТН	
	Кредит Харилцах данс		250,000,000 ТН

2. Жил 1: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Зээлийн авлага	22,924,730 ТН	
	Кредит Хүүний орлого		22,924,730 ТН

*Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (199,345,480 ТН х 11.5%) хуримтлуулах.*

Дебит	Харилцах данс	15,000,000 ТН	
	Кредит Зээлийн авлага		15,000,000 ТН

*Хүүний төлөлт, 250 сая ТН х 6%.*



САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

3. Жил 2: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Зээлийн авлага	23,836,074 ТН	
Кредит	Хүүний орлого		23,836,074 ТН

*Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (207,270,210 ТН х 11.5%) хуримтлуулах.*

Дебит	Харилцах данс	15,000,000 ТН	
Кредит	Зээлийн авлага		15,000,000 ТН

*Хүүний төлөлт, 250 сая ТН х 6%.*

4. Жил 3: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Зээлийн авлага	24,852,223 ТН	
Кредит	Хүүний орлого		24,852,223 ТН

*Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (216,106,284 ТН х 11.5%) хуримтлуулах.*

Дебит	Харилцах данс	15,000,000 ТН	
Кредит	Зээлийн авлага		15,000,000 ТН

5. Жил 4: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Зээлийн авлага	25,985,228 ТН	
Кредит	Хүүний орлого		25,985,228 ТН

*Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (225,958,228 ТН х 11.5%) хуримтлуулах.*

Дебит	Харилцах данс	90,000,000 ТН	
Кредит	Зээлийн авлага		90,000,000 ТН

*250 сая ТН х 6%-ийн хүүний төлөлт + 75 сая ТН-ийн үндсэн дүнгийн буцаан төлөлт.*

6. Жил 5: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Зээлийн авлага	18,623,530 ТН	
Кредит	Хүүний орлого		18,623,530 ТН

*Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (161,943,735 ТН х 11.5%) хуримтлуулах.*

Дебит	Харилцах данс	85,500,000 ТН	
Кредит	Зээлийн авлага		85,500,000 ТН

*175 сая ТН х 6%-ийн хүүний төлөлт + 75 сая ТН-ийн үндсэн дүнгийн буцаан төлөлт.*

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

7. Жил 6: Байгууллага нь дараах зүйлсийг хүлээн зөвшөөрнө:

Дебит	Зээлийн авлага	10,932,735 ТН	
Кредит	Хүүний орлого		10,932,735 ТН

Үр ашигт хүүний аргыг ашиглан хүүг (95,067,265 ТН x 11.5%) хуримтлуулах.

Дебит	Харилцах данс	106,000,000 ТН	
Кредит	Зээлийн авлага		106,000,000 ТН

Үндсэн дүнгийн буцаан төлөлтийг хүлээн зөвшөөрөх.

Тооцоолол:

**Хүснэгт 1: Хорогдуулгын хуваарь (6 хувийн хүүтэй гэрээний эргэн төлөлтийг ашиглах)**

	Жил 0 Мян.ТН	Жил 1 Мян.ТН	Жил 2 Мян.ТН	Жил 3 Мян.ТН	Жил 4 Мян.ТН	Жил 5 Мян.ТН	Жил 6 Мян.ТН
Үндсэн дүн	250,000	250,000	250,000	250,000	250,000	250,000	250,000
Хүү	-	15,000	15,000	15,000	15,000	10,500	6,000
Төлөлт	-	15,000	15,000	15,000	90,000	85,500	106,000
<b>Үлдэгдэл</b>	<b>250,000</b>	<b>250,000</b>	<b>250,000</b>	<b>250,000</b>	<b>175,000</b>	<b>100,000</b>	<b>-</b>

**Хүснэгт 2: Гэрээний мөнгөн гүйлгээг дискаунтчлах (11.5 хувийн зах зээлийн хүүнд үндэслэсэн)**

	Жил 1 Мян.ТН	Жил 2 Мян.ТН	Жил 3 Мян.ТН	Жил 4 Мян.ТН	Жил 5 Мян.ТН	Жил 6 Мян.ТН
Үндсэн дүнгийн үлдэгдэл	250,000	250,000	250,000	175,000	100,000	-
Хүүний өглөг	15,000	15,000	15,000	15,000	10,500	6,000
Нийт төлөлт (үндсэн дүн ба хүү)	15,000	15,000	15,000	90,000	85,500	106,000
Төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнэ	13,452,915	12,065,394	10,820,981	58,229,497	49,612,576	55,164,117
Төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнүүдийн нийт дүн						<u>199,345,480</u>
Төлсөн мөнгөн дүн						250,000,000
Хасах: Мөнгөн зарлагын өнөөгийн үнэ цэнэ (анх хүлээн зөвшөөрөх үеийн зээлийн бодит үнэ цэнэ)						<u>199,345,480</u>
Арилжааны бус орлого гэж хүлээн зөвшөөрөх уг зээлийн зах зээлийн бус хэсэг						<u>50,654,520</u>

**Хүснэгт 3: Үр ашигт хүүний аргыг ашиглан зээлийн үлдэгдэл ба хүүг тооцоолох**

	Жил 1 ТН	Жил 2 ТН	Жил 3 ТН	Жил 4 ТН	Жил 5 ТН	Жил 6 ТН
Үндсэн дүн	199,345,480	207,270,210	216,106,284	225,958,228	161,943,735	95,067,265
Хүүний хуримтлуулалт	22,924,730	23,836,074	24,852,223	25,985,228	18,623,530	10,932,735
Хүү ба үндсэн дүнгийн төлөлт	15,000,000	15,000,000	15,000,000	90,000,000	85,500,000	106,000,000
<b>Үлдэгдэл</b>	<b>207,270,210</b>	<b>216,106,284</b>	<b>225,958,228</b>	<b>161,943,735</b>	<b>95,067,265</b>	<b>-</b>

**Нэрлэсэн төлбөртэй гаргасан санхүүгийн баталгааны гэрээ**

- ҮЖ43. В байгууллага нь А улсын автомашины гол үйлдвэрлэгч юм. 201V оны 01 дүгээр сарын 01-нд А засгийн газар (гаргагч) нь В байгууллагын (зээлдэгчийн) 30 жилийн хугацаатай авсан бөгөөд 201X онд болон 204Z онд тус бүр 25 сая ТН (тоолох нэгж)-ээр хоёр удаа тэнцүү дүнгээр хэсэгчлэн буцаан төлөх 50 сая ТН-ийн зээлийг үл төлсөний санхүүгийн үр дагаврыг Б байгууллагад (зээмшигч) нөхөн олгох санхүүгийн баталгааны гэрээг Б байгууллагатай байгуулсан. В байгууллага нь А засгийн газарт 30,000 ТН-ийн нэрлэсэн төлбөрийг төлнө. А засгийн газартай хэлцэл хийхийн өмнө В байгууллага нь баталгаа гаргуулахаар бусад олон байгууллагад хандсан боловч аль ч байгууллага нь ийм баталгаа гаргахад бэлэн байгаагүй. А улсын болон хөрш Г, Д улсуудын автомашин үйлдвэрлэлийн салбарт ийм санхүүгийн баталгаа гаргасан сүүлийн үеийн жишээ байгаагүй. Үнэлгээний арга зүйг ашиглах нь бодит үнэ цэнийн талаархи найдвартай хэмжилтийг бий болгохгүй тул А засгийн газар нь үнэлгээний арга зүй ашиглах боломжгүй гэж дүгнэсэн. Иймээс А байгууллага нь уг санхүүгийн баталгааны гэрээг УСНББОУС 19-ийн дагуу хэмжихээр шийдвэрлэсэн.
- ҮЖ44. 201V оны 12 сарын 31-нд В байгууллагын санхүүгийн байдал ба үр дүнг нягталж шалгаснаар А засгийн газар нь уг санхүүгийн баталгааны гэрээтэй холбоотойгоор Б байгууллагад төлөх одоогийн үүрэг байхгүй гэж тодорхойлсон. А засгийн газар нь санхүүгийн байдлын тайландаа өр төлбөр хүлээн зөвшөөрөөгүй. А засгийн газар нь санхүүгийн баталгааны гэрээний хувьд УСНББОУС 30, *Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга*-ын дагуу бодит үнэ цэнэ ба зээлийн эрсдэлтэй холбоотой тодруулгыг хийсэн. Мөн тус байгууллага нь 50 сая ТН-ийн дүнтэй болзошгүй өр төлбөрийг УСНББОУС 19-ийн дагуу тодруулсан. В байгууллагын төлөх нэрлэсэн төлбөрийн хувьд А засгийн газар нь өөрийн санхүүгийн үр дүнгийн тайландаа 1,000 ТН-ийн орлогыг хүлээн зөвшөөрсөн.
- ҮЖ45. 201Z онд автомашины үйлдвэрлэлийн салбарын бууралт үүссэн бөгөөд энэ нь В байгууллагад нөлөө үзүүлсэн. Хэдийгээр өөрийн хүүний төлбөрийн үүргийг биелүүлсэн боловч В байгууллага нь дампуурлаас сэргийлэхийн тулд үндсэн дүнгийн эхний буцаан төлөлтийг хийгээгүй. А засгийн газар нь В байгууллагын санхүүгийн байдал сэргэх магадлал багатай гэж тодорхойлсон боловч В байгууллагад бүтцийн өөрчлөлт хийж чадах боломжит худалдан авагчтай (Г байгууллага) хэлцэл хийж эхэлсэн. Г байгууллага нь Б байгууллагад төлөх зээлийн сүүлийн хэсэгчилсэн

төлбөрийг хариуцаж болох боловч эхний хэсэгчилсэн төлбөрийг төлөхгүй гэдгээ илэрхийлсэн. А засгийн газар нь 25 сая ТН-ийн зардал ба өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн ба уг 25 сая ТН-ийн болзошгүй өр төлбөрт тодруулга хийсэн.

### **УСНББОУС 23 ба УСНББОУС 29-ийн хэмжилтийн шаардлагуудын хоорондох харилцан уялдаа**

#### *Танилцуулга*

- ҮЖ46. Хувь хүн нь хөрөнгийн биржид бүртгэлтэй Х байгууллагын хувьцааг 20Х8 оны 01 дүгээр сарын 01-нд улсын секторын А байгууллагад хандивласан. Тухайн өдөр Х байгууллагын хувьцаа нь 1,000,000 ТН-ийн бодит үнэ цэнэтэй байсан. 20Х8 оны 12 дугаар сарын 31-нд хувьцааны бодит үнэ цэнэ нь 900,000 ТН болсон. Тохиролцооны нэг хэсэг болгон А байгууллага нь хувьцааг өөрийн нэр дээр шилжүүлэхийн тулд шилжүүлгийн шимтгэлийг хариуцна. Энэ зардлын дүн 10,000 ТН байв.
- ҮЖ47. Биржид бүртгэлтэй уг Х байгууллага нь харилцаа холбооны дэд бүтцийн болон холбогдох үйлчилгээг олон нийтэд үзүүлдэг. 20Х9 онд харилцаа холбооны салбарт шинэ технологи нэвтэрсэн бөгөөд Х байгууллагын ашиглаж байсан дэд бүтэц болон тоног төхөөрөмж нь үндсэндээ бүрэн хоцрогдолд орсон. Энэ нь хөрөнгийн биржид бүртгэлтэй Х байгууллагын үнэ цэнэд удаан хугацааны бууралт гарахад хүргэсэн. 20Х9 оны 12 дугаар сарын 31-нээрх үнэ цэнийн бууралтын гарз нь 700,000ТН байв. А байгууллага нь хувьцааны хөрөнгө оруулалтыг борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө гэж тайлагнах нягтлан бодох бүртгэлийн бодлоготой. Энэхүү тохиролцоог гэрээний хэлцэл гэж үзэх бөгөөд уг хандив болон 20Х8 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тухайн байгууллагын тайлант үеийн хувьд одоогийн үүрэг үүсээгүй байна.

#### *Шинжилгээ*

- ҮЖ48. А байгууллага нь хувьцааг хандив байдлаар хүлээн авсан тул тус байгууллага нь уг олж эзэмшсэн хувьцаа болон холбогдох арилжааны бус орлогыг анх хүлээн зөвшөөрөхдөө УСНББОУС 23-ыг мөрдөнө. Гэвч А байгууллага нь санхүүгийн хөрөнгө олж авсан учраас УСНББОУС 23 болон УСНББОУС 29-ийн анхны хэмжилтийн шаардлагуудыг харгалзан үзнэ.
- ҮЖ49. УСНББОУС 23 нь арилжааны бус орлогын ажил гүйлгээний нэг хэсэг байдлаар олж эзэмшсэн хөрөнгийг анх түүний бодит үнэ цэнээр хэмжинэ гэж заасан бол УСНББОУС 29 нь санхүүгийн хөрөнгийг анх түүний бодит үнэ цэнээр хэмжих ба тэдгээрийн ангиллаас хамааран ажил гүйлгээний зардлыг тусган оруулж эсвэл оруулахгүй байж болно гэж заасан. А байгууллага нь хувьцааны хөрөнгө оруулалтыг борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө гэж тайлагнах нягтлан бодох бүртгэлийн бодлоготой тул 10,000 ТН-ийн ажил гүйлгээний зардлыг хувьцааны анхны хэмжилтийн 1,000,000 ТН-ийн үнэ цэнэ дээр нэмнэ.
- ҮЖ50. Хувьцааны дараагийн тайлант үеийн хэмжилт ба үл хүлээн зөвшөөрөлтийн талаар УСНББОУС 29-д заасан байдаг. Байгууллага нь хувьцааны хөрөнгө

САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨЛТ БА ХЭМЖИЛТ

оруулалтыг борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө гэж ангилж байгаа нь уг хувьцааг бодит үнэ цэнээр хэмжих ба бодит үнэ цэнэийн дараагийн тайлант үеийн аливаа өөрчлөлтийг цэвэр хөрөнгө/өмчид хүлээн зөвшөөрнө гэсэн үг юм. Харин үнэ цэнийн бууралтын гарзыг түүний үүссэн тухайн тайлант үед ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Анхны олж эзэмшилтийн болон тайлангийн өдрүүдээрх журналын бичилт нь дараах байдалтай байна:

1. Хандиваар хувьцааг олж эзэмших

Дебит	Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө (Х байгууллага дахь хөрөнгө оруулалт)	1,010,000
Кредит	Арилжааны бус орлого	1,000,000
Кредит	Харилцах данс (Төлсөн шилжүүлэлтийн хураамж)	10,000

2. 20X8 оны 12 дугаар сарын 31-нээрх дараагийн үеийн хэмжилт:

Дебит	Цэвэр хөрөнгө/өмч (хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн тохируулга)	110,000
Кредит	Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө (Х байгууллага дахь хөрөнгө оруулалт)	110,000

3. 20X9 оны 12 дугаар сарын 31-нээрх дараагийн тайлант үеийн хэмжилт:

Дебит	Үнэ цэнийн бууралтын гарз (ашиг, алдагдал)	700,000
Кредит	Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө	700,000

## НББОУС 39-ТЭЙ ХАРЬЦУУЛАЛТ

УСНББОУС 29, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*-ийг НББОУС 39, *Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт*-ээс (үүн дотроо, 2008 оны 12 дугаар сарын 31 хүртэлх нэмэлт өөрчлөлтүүд, түүнчлэн НББОУС3-өөс 2009 оны 4 дүгээр сард гаргасан, *СТОУС-ын Сайжруулалтууд*-ын нэг хэсэг байдлаар НББОУС 39-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүдөөс) үндсэндээ бэлтгэсэн болно. УСНББОУС 29 ба НББОУС 39-ийн хоорондын гол зөрүү нь дараах байдалтай байна:

- УСНББОУС 29 нь тэг (0) буюу нэрлэсэн төлбөртэйгээр байгуулсан санхүүгийн баталгааны гэрээ болон хөнгөлөлттэй зээлийг тайлагнах талаархи мөрдөх нэмэлт заавар удирдамжийг агуулсан байдаг.
- УСНББОУС 29 нь зарим тохиолдолд НББОУС 39-д дурдсанаас өөр нэр томъёог ашигладаг. Хамгийн том жишээ нь “санхүүгийн үр дүнгийн тайлан” ба “цэвэр хөрөнгө/өмч” гэсэн нэр томъёоны хэрэглээ юм. НББОУС 39 дэх адилтгах нэр томъёо нь “дэлгэрэнгүй орлогын тайлан тусдаа орлогын тайлан (хэрэв толилуулдаг бол)” ба “өмч” юм.
- УСНББОУС 29 нь “орлого” /revenue/ ба “орлого” /income/ нэр томъёог ялган авч үздэггүй. Харин НББОУС 39 нь “орлого” /revenue/ ба “орлого” /income/ нэр томъёог өөр хооронд нь ялган авч үздэг бөгөөд “орлого” /income/ нэр томъёо нь “орлого” /revenue/ нэр томъёоноос илүү өргөн утгатай байдаг.
- СТОУТХ 9, *Дагалдах Үүсмэл Хэрэглүүрийн Дахин Үнэлэлт* болон СТОУТХ 16, *Гадаад Үйл Ажиллагаанд Оруулсан Цэвэр Хөрөнгө Оруулалтын Хейжийн зарчмуудыг УСНББОУС 29-д бүрэн эрх бүхий хавсралтууд байдлаар тусган оруулсан.*



# УСНББОУС



International  
Federation  
of Accountants®